



МОНГОЛ УЛСЫН  
ХҮНИЙ ЭРХИЙН  
ҮНДЭСНИЙ КОМИСС



НЭГДСЭН ҮНДЭСНИЙ  
БАЙГУУЛЛАГА  
МОНГОЛ УЛС

# ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ БА МОНГОЛ УЛС

Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит илтгэлүүд, НҮБ-ын гэрээний хороод, хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлгээс Монгол Улсад өгсөн зөвлөмжийн эмхэтгэл  
(1971-2020)

## ХОЁРДУГААР БОТЬ

Улаанбаатар хот  
2021 он

ННА – 67.3  
ДАА – 340.009  
М – 692

Энэхүү эмхэтгэлийг  
НҮБ–ын Монгол Улс дахь Суурин зохицуулагчийн  
газрын санхүүжилтээр хэвлэв.

## **ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ БА МОНГОЛ УЛС**

ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН  
ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ЭЭЛЖИТ ИЛТГЭЛҮҮД, НҮБ–ЫН ГЭРЭЭНИЙ ХОРООД,  
ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС  
МОНГОЛ УЛСАД ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ЭМХЭТГЭЛ  
(1971–2020)

Эмхэтгэсэн: Г.Агар–Эрдэнэ  
Ч.Ариунаа  
Э.Туул

Эхийг бэлтгэсэн: Ч.Эрдэнэбат

Хэвлэлийн хуудас: 79.0 х.х.

ISBN 978–9919–9531–8–8

“Бэмби сан” ХХК–д хэвлэв.  
Улаанбаатар хот 2021 он

# ГАРЧИГ

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХҮҮХДИЙН ЭРХИЙН КОНВЕНЦ

6.1	Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын анхдугаар илтгэл (1994 он)	8
6.2	Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит хоёр дахь илтгэл (2003 он)	54
6.3	Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын хоёр дахь тайлан, илтгэлийг хэлэлцээд НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хорооноос өгсөн зөвлөмж	103
6.4	Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын үндэсний гурав, дөрөвдүгээр тайлан илтгэл	122
6.5	Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын гурав, дөрөвдүгээр илтгэлийг хэлэлцээд НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хорооноос өгсөн зөвлөмж	213
6.6	Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын тавдугаар тайлан	234
6.7	Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын тавдугаар тайлан, илтгэлийг хэлэлцээд НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хорооноос өгсөн зөвлөмж	304
6.8	Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг нэмэлт протоколын наймдугаар зүйлийн дагуу гишүүн орны өргөн барьсан тайлангийн зөвлөмж	322
6.9	Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцийн нэмэлт протоколын 12(1) дүгээр зүйлийн дагуу гишүүн орны өргөн барьсан анхдугаар тайлангийн зөвлөмж	325

## **ДОЛООДУГААР БҮЛЭГ**

### **ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР БУЮУ ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦ**

- 7.1 Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн талаарх Монгол Улсын анхдугаар илтгэл (2009 он) 332
- 7.2 Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн талаарх Монгол Улсын анхдугаар илтгэлийг хэлэлцэж Эрүүдэн Шүүхийн Эсрэг Хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмж (2010 он) 367
- 7.3 Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн хэрэгжилтийн тухай Монгол Улсын хоёрдугаар илтгэл (2015 он) 379
- 7.4 Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын хоёрдугаар илтгэлийг хэлэлцээд НҮБ-ын Эрүүдэн Шүүхийн Эсрэг Хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмж (2016 он) 420
- 7.5 Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан дэд хороо Монгол Улсад 2017 оны 09 сарын 11-ээс 20-ны өдрүүдэд хийсэн айлчлал: Ажиглалт болон Оролцогч улсад хандсан зөвлөмжүүд 433
- 7.6 Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг асуудал хариуцсан хороонд Монгол Улсаас конвенцийн хэрэгжилтийн талаар хүргүүлэх ээлжит гурав дахь удаагийн тайлан (2020 он) 457

## **НАЙМДУГААР БҮЛЭГ**

### **ХҮЧЭЭР АЛГА БОЛГОХООС БҮХ ХҮНИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ НҮБ-ЫН КОНВЕНЦ**

- 8.1 Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай  
НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийн талаарх  
Монгол Улсын Засгийн газрын анхны тайлан 540

## **ЕСДҮГЭЭР БҮЛЭГ**

### **ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

- 9.1 Монгол Улс дахь хүний эрхийн төлөв  
байдлын талаарх үндэсний илтгэл 560
- 9.2 Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын  
талаарх үндэсний илтгэлийг хэлэлцээд НҮБ-ын  
Хүний Эрхийн Зөвлөлөөс өгсөн зөвлөмж 584
- 9.3 Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын  
талаарх үндэсний илтгэлийг НҮБ-ын  
Хүний Эрхийн Зөвлөл хэлэлцсэн тухай  
тайлан мэдээ 604
- 9.4 Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын  
талаарх үндэсний хоёрдугаар илтгэл 621
- 9.5 Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын  
талаарх үндэсний хоёрдугаар илтгэлийг хэлэлцээд  
НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлөөс өгсөн зөвлөмж 641
- 9.6 Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг  
Монгол Улсын Засгийн газрын дунд хугацааны  
хэрэгжилтийн тайлан 657
- 9.7 Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын  
талаарх үндэсний гуравдугаар илтгэл 753
- 9.8 НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн хүний эрхийн төлөв  
байдлыг хянан хэлэлцэх ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг  
(UPR)-ийн ажлын хэсгийн 36 дугаар чуулганаар  
Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын  
талаарх үндэсний гуравдугаар илтгэлийг хэлэлцүүлэх  
үеэр бусад улсаас өгсөн зөвлөмж 775

## АРАВДУГААР БҮЛЭГ

### НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ТУСГАЙ ИЛТГЭГЧ НАРЫН ТАЙЛАН

- |  |     |
|--|-----|
| 10.1 НҮБ–ын Хоол хүнсээр хангагдах эрхийн асуудал хариуцсан тусгай илтгэгч Жан Зиглерийн тайлан  | 790 |
| 10.2 НҮБ–ын Эрүү шүүлтийн асуудал хариуцсан тусгай илтгэгч Манфред Новакийн тайлан   | 817 |
| 10.3 НҮБ–ын Сурч боловсрох эрх хариуцсан тусгай илтгэгч Вернор Муноз Виллалобосын тайлан   | 837 |
| 10.4 НҮБ–ын Нэн ядуурал болон хүний эрхийн асуудал хариуцсан тусгай илтгэгч Магдалена Сепулведа Кармонагийн тайлан   | 857 |
| 10.5 НҮБ–ын Хүний эрх ба хүрээлэн буй орчны асуудал хариуцсан тусгай илтгэгч Жон Ноксийн тайлан  | 884 |
| 10.6 НҮБ–ын Хүний эрх, ундны усны аюулгүй байдал, ариун цэврийн байгууламжийн асуудал хариуцсан тусгай илтгэгч Лео Хеллерын Монгол Улсад хийсэн айлчлалын дүгнэлт  | 908 |
| 10.7 НҮБ–ын Хүний эрхийг хамгаалагчийн асуудал хариуцсан тусгай илтгэгч Мишель Форстын 2019 оны 4 дүгээр сарын 30–наас 5 дугаар сарын 13–нд Монгол Улсад ажилласан томилолтын тайлан   | 921 |
| 10.8 НҮБ–ын Улсын гадаад өр болон холбогдох бусад санхүүгийн үүрэг хариуцлагаас хүний эрх, тухайлбал эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ бүрэн эдлэхэд үзүүлэх нөлөөллийг хариуцсан бие даасан шинжээч Хуан Пабло Богославскийн мэдээлэл | 937 |

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

**ХҮҮХДИЙН  
ЭРХИЙН ТУХАЙ  
КОНВЕНЦ**

## **6.1 ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН АНХДУГААР ИЛТГЭЛ (1994 ОН)**

### **Оршил**

#### **А. Монгол Улс**

1. Монгол Улс зүүн хойд Азид байрладаг. 1,566,500 кв.м нутаг дэвсгэртэй. Газар зүйн гурван гол бүсэд хуваагддаг. Баруун хойд хэсэгтээ ойд мод бүхий уулархаг, өмнөд хэсэгтээ говийн бүстэй бөгөөд далайн түвшнөөс 1500 метр өндөр өргөгдсөн, богино өвс бүхий тал хээр нутагтай.

2. Монгол Улс нийт 2,1 сая хүн амтай бөгөөд нийт хүн амын 49 хувь нь 18-аас наснаас доош насныхан. Хүүхдүүд суурин газрын нийт хүн амын 47,6 хувийг, хөдөө орон нутгийн нийт хүн амын 51,2 хувийг эзэлдэг. Нийт хүн амын 52 хувиас дээш нь хот суурин газар амьдардаг бөгөөд хүн амын гуравны нэг нь Улаанбаатар, Дархан, Эрдэнэт болон Чойр зэрэг хотуудад төвлөрч амьдардаг. Хүн амын үлдсэн хувь нь хөдөө орон нутагт амьдардаг. Зарим малчид зуны цагт хөдөө гарч мал маллан, өвлийн улиралд суурин газар нүүж ирдэг.

3. 1990 он хүртэл хүн амын жилийн дундаж өсөлт 2,5 хувь байсан боловч сүүлийн 4 жилд энэ нь буурч, 1993 онд 1,8 хувь болсон. Өсөлтийн түвшин буурсан нь Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих явцад тохиолдож буй эдийн засаг, нийгмийн бэрхшээл, хоол хүнсний хомсдол болон амьжиргааны зардал ихэссэн зэрэг хүчин зүйлүүдээс хамаарч үр хөндөлт нэмэгдэн, хүмүүсийн хүүхэдтэй болох сонирхол буурсантай холбоотой.

4. 1993 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан “Хүн ам зүйн талаар төрөөс баримтлах бодлогод” хүн амын жилийн дундаж өсөлт 2 хувиас доошгүй байхаар заасан. Хүн ам зүйн талаарх одоогийн төрийн бодлого болон хүүхдүүдийн тоо, мөн хүүхэд төрүүлэх насны эмэгтэйчүүдийн тоо нэмэгдэж байгаа нь хүн ам өсөхөд нөлөөлнө.

5. Монгол Улс зөвхөн улирлаар бус харин өдрөөр өөрчлөгддөг хур тунадас багатай эх газрын цаг агаартай. Ихэнх газруудад жилийн дундаж цаг агаар 0 градус байдаг. Хүйтэн бөгөөд хуурай цаг агаар болон тасралтгүй салхилах салхи хүүхдийн амьсгалын хурц халдварт өвчнөөр өвчлөх гол шалтгаан нь болж байна.

6. Мал бол Монгол Улсын эдийн засгийн үндэс юм. 25 сая толгой мал нь нийт хүн амаас 10 дахин их байна.

#### **Б. Улс төр, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал**

7. Зах зээлийн эдийн засагт шилжсэнээр 1990 оноос хойш Монгол Улсад улс төр, нийгэм, эдийн засгийн гүнзгий шинэчлэл явагдаж байна. 1992 оны 1 дүгээр сард шинэ



Үндсэн хууль батлагдсан. Үндсэн хуулиар засаглалын ардчилсан парламентын тогтолцоо, иргэний эрх чөлөө болон бусад эрхийг баталгаажуулсан. Эрүүл аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах, сурч боловсрох эрхүүд хуульчлагдан баталгаажсан. Олон намын ардчилсан тогтолцоо бий болсон.

8. Монгол Улс одоогийн байдлаар улс төр, нийгэм, эдийн засгийн шинэчлэл хийж буй бусад орнуудын нэгэн адил шилжилтийн үеийн олон бэрхшээл ялангуяа эдийн засгийн бэрхшээлтэй тулгарч байна. Сүүлийн гурван жилийн Монгол Улсын эдийн засгийн хямралыг жишээгээр харуулбал инфляцийн түвшин өндөр (1991 оны 1 дүгээр сараас 1993 оны 8 дугаар сарын хооронд хоол хүнсний зүйлийн үнэ 1,976 хувиар, бусад үнэ 1,554 хувиар өссөн), хөдөлмөр эрхлэх насны ажилгүй хүмүүсийн тоо 16 хувиар өссөн ба дотоодын нийт бүтээгдэхүүн 25 хувиар буурсан. Ажилгүйдлийн огцом өсөлт болон үнийн өсөлтөөс хамаарч хүн амын бодит орлого огцом буурч, ядуу хүмүүсийн тоо өсөж байна. Хүн амын бодлого, хөдөлмөрийн яамнаас гаргасан статистикийн мэдээгээр Монгол Улсын хүн амын 28,4 хувь нь өнөөдөр амьжиргааны баталгаажих доош түвшингээс хэт доогуур амьдарч байна. Тиймээс зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд нийцүүлэн нийгмийн үйлчилгээний салбарыг үндсээр нь өөрчлөх шаардлага тулгарч байна.

9. Гэсэн хэдий ч, Монгол Улсын Засгийн газар аль болох богино хугацаанд олон улсын болон хоёр талын хамтын ажиллагааны тусалцаанаас хэт хамааралтай байдлыг арилгах, хүчтэй зах зээлд тулгуурласан эдийн засгийн дэд бүтцийг бий болгох эдийн засгийн шинэчлэл.

10. Эдийн засгийг хувьчлах анхны арга хэмжээ Монголын айл өрх бүрт өмч хувьчлалын эрхийн бичиг тарааж өгснөөр хэрэгжсэн. Хоёр жилийн хугацаанд нийт төрийн өмчийн тавны нэг нь хувьчлагдсан. Тиймээс томоохон хувьчлал бараг хийгдэж гүйцсэн. Монголын эдийн засгийн бүтцэд тодорхой өөрчлөлт гарч хувийн хэвшлийн үүрэг, эзлэх жин хэмжээ нэмэгдэж байна. Малын 90 хувиас илүү нь хувьчлагдаж, нийт үйлдвэрлэлийн бараг 50 хувь нь хувийн эсвэл хувьчлагдсан байгууллагуудаас хамаарч байна. Худалдаа, хүнс, нийтийн үйлчилгээ болон барилгын салбарт хийгдэж буй ажлын 80–90 хувийг хувийн хэвшлийн байгууллагууд хийж байна.

11. Үүний зэрэгцээ өмч хувьчлал хүүхдүүдэд сөргөөр нөлөөлсөн. Малыг хувьчилснаар малчин өрхийн хүүхдүүд эцэг, эхдээ туслахын тулд сургуулиа орхисон. Түүнчлэн хүүхдийн үйл ажиллагаанд зориулан барьсан барилгууд болон хүүхдийн кино театрууд хувьчлагдаж, өөр зорилготой үйл ажиллагаа явуулах болсон.

12. Энэ хугацаанд үнэ чөлөөлөгдөж, Засгийн газар 1993 онд хөврөх валютын үнийг нэвтрүүлж, улмаар валютын ханш өсөхөд нөлөөлсөн. Эдгээр зохицуулалтын үр дүнд тариф болон үнийн тогтворжилтод нааштай өөрчлөлт бий болж байна. Гэвч төсвийн байгууллагын ажилтнууд, тэтгэвэр тэтгэмжээр амьдардаг болон орлого багатай олон хүүхэдтэй өрхүүдийн амьдрал маш хүнд хэвээр байна. Засгийн газарт тэдгээрийн орлого, цалинг нэмэгдүүлэх нэмэлт эх үүсвэр байхгүй тул эдгээр хүмүүсийг жижиг хэмжээний аж ахуй болон зарим бизнес эрхлүүлэх арга хэмжээ авч байна. Иргэдээ хөгжүүлэх талаарх энэ бодлого нь зах зээлийн эдийн засгийн тогтолцооны төрийн нийгмийн бодлогын гол үндэс болоод байна.

13. 1990 оноос өмнө тахир дутуу хүмүүс, эхчүүд болон хүүхэдтэй холбоотой бүх төрлийн тэтгэвэр, тэтгэмж, амаржсаны тэтгэмж, халамжийг эрх нь үүссэн хүмүүст тэгш байдлаар хуваарилж байсан. Гэвч 1990–ээд оноос хойш Засгийн газар эдийн засаг, нийгмийн өөрчлөлтөд нийцсэн нийгмийн хамгааллын шинэ тогтолцоог бий болгож, эмзэг бүлгийн хүмүүсийн нийгмийн баталгааг хангах хэд хэдэн арга хэмжээ авсан. Нийгмийн даатгалын сүлжээний төвлөрсөн зохицуулалтад өөрчлөлт хийж нийгмийн даатгалын санг улсын төсвөөс салгаж орон нутгийн түвшинд бие даан ажиллах зарчмыг нэвтрүүлсэн. Нэн тэргүүнд хийх ажил бол одоогийн бүх хүмүүст олгодог нийгмийн хамгааллын тогтолцоог өөрчилж өндөр настан, тахир дутуу болон ядуу хүмүүст чиглэсэн тогтолцоог бий болгох явдал юм.

14. Ажилгүйдлийн түвшин өсөж буй нөхцөлд ажилгүй хүмүүст тэтгэмж олгох эх үүсвэрийн сан бий болгох, тэдгээрийг нийгмийн хамгааллын тогтолцоонд хамруулах хэрэгцээ шаардлага бий болоод байна.

15. Сүүлийн гурван жилд Засгийн газрын эрүүл мэнд, боловсрол болон бусад нийгмийн даатгалд зарцуулах зардал огцом буурсан. Энэ нь хүүхэд, эмэгтэйчүүдэд сөргөөр нөлөөлсөн. Үүнд:

- а. өрхийн бодит орлого огцом буурснаас хоол хүнсний хангамж, чанар эрс муудаж, өрхүүд үнийн өсөлтөөс хамаарч хүүхэддээ наад захын хэрэгцээт бүтээгдэхүүн болон хувцсыг худалдан авах боломжгүй болж байна. Энэ нь ялангуяа эцэг, эх нь архичин хүүхдүүд болон ганц бие эцэг, эхтэй хүүхдүүдэд сөргөөр нөлөөлж байна.
- б. эрүүл мэнд, боловсрол болон нийгмийн салбарын бусад үйлчилгээний чанар муу байгаа нь ялангуяа ядуу гэр бүл болон нийгмийн эмзэг бүлгүүдэд сөргөөр нөлөөлж байна.

### **В. Хүүхэд өсгөж, хүмүүжүүлэх Монголын уламжлалт арга**

16. Монголын хүүхэд өсгөж хүмүүжүүлэх уламжлалт аргууд эцэг, эхийн нүүдэлчин амьдралын хэв маяг, туршлагатай нягт холбоотой. Тэдгээрийн туршлагын гол санаа нь хүүхдэд хөдөлмөрийн дадлага олгох, улмаар ажилч, хичээнгүй иргэн болгон төлөвшүүлэхэд оршдог. Монголчуудын уламжлалт арга нь цаг уурын хатуу хүнд нөхцөлд хөршүүдтэйгээ эв найрамдалтай хамтран амьдарч, мал маллах, нүүдэлчин амьдралын дэг жаягийг дагаж амьдрахын зэрэгцээ оюун ухааны болон соёлын үнэт зүйлсээ хөгжүүлэхтэй хосолдог. Хөдөлмөрийн үнэ цэнийг ойлгуулахын тулд Монголчууд янз бүрийн насны хүүхдүүдийн онцлогт тохирсон төрөл бүрийн ажлыг хийлгэдэг.

17. Монголчууд үр хүүхдээ өсгөх өвөг дээдсийнхээ мэргэн ухаан, уламжлалыг өвлөж авсан. Эдгээрийн нэг арга нь Монголын уламжлалт тоглоомуудыг ашиглах явдал юм. Эдгээр тоглоомууд нь сургуулийн өмнөх насны хүүхдийг хөгжүүлэх гол хэрэгсэл болдог. Түүнчлэн хүүхдийг хөгжүүлэхэд ардын үлгэр болон уран зохиол чухал үүрэг гүйцэтгэдэг. Монгол ардын үлгэрүүд нь үндэсний сонгодог утга зохиолыг үндэс суурь болохын зэрэгцээ уламжлалт зан заншил, соёл, хүмүүжлийн үнэт зүйлийг сургахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Бидний өвөг дээдэс ардын үлгэрийг зөвхөн зугаа цэнгэл тайлах

арга гэж үздэггүй байсан. Хүүхдүүд маш бага байхаасаа эхлэн ардын үлгэр сонсож, амьдралын арга ухааныг сурдаг. Монголын үндэсний ардын үлгэрүүд хүүхдэд биеийн болон оюун ухааны чадвараа хөгжүүлэхэд тусалдаг түргэн хэллэг болон оньсого таавраар баялаг юм.

18. Монголчууд хүүхдийг өсгөж хүмүүжүүлэх бусад орны туршлагыг нэвтрүүлэх, энэ салбар дахь өөрсдийн мэдлэгээ баяжуулахад ихээхэн анхаардаг. Улс орны хөгжил, амьдралын шинэ хэв маяг бий болж буй нь дэлхийн соёл иргэншилтэй нэгдэх хэрэгцээ шаардлагыг бий болгож байна. Тиймээс хүүхэд, залуучуудын талаар төрөөс баримтлах бодлого нь хүүхдэд Монголын философи, онцлог сэтгэлгээ, үндэсний бичиг, хэл, соёл болон уламжлалыг сайн сургахын зэрэгцээ хүн төрөлхтний соёл иргэншил болон соёлын үнэт зүйлсийн талаар мэдэх боломж олгох нөхцөлийг бий болгоход гол анхаарлаа хандуулж байна.

19. Энэхүү төрийн бодлогын хүрээнд Шинжлэх ухаан, боловсролын Яам, Эрүүл мэндийн яам, Соёлын яам, Монголын хүүхдийн үндэсний төв болон Монголын эмэгтэйчүүдийн холбоо, Монголын ардчилсан эвсэл зэрэг улс олон нийтийн байгууллагууд 1992 онд хүүхдийг сургах үйл ажиллагаандаа ашиглах “Өв”, “Амьдралын мэргэн ухаан, гэр бүл, сургууль” зэрэг төслийг хамтран боловсруулсан.

### **I хэсэг. Хүүхдийн эрхийн тухай конвенцийг хэрэгжүүлэх талаар авч хэрэгжүүлсэн гол арга хэмжээнүүд**

#### **A. Конвенцийг хэрэгжүүлэх талаарх төрийн бодлого ба авсан арга хэмжээнүүд**

20. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1994 оны 5 дугаар сарын 24-ны 126 дугаар зарлигаар Монгол Улс нь Хүүхдийн эрхийн тухай конвенцид албан ёсоор нэгдэн орсон. Үүнээс хойш улс орны ирээдүй болсон хүүхдийн эрх ашигтай холбоотой асуудлууд төрийн болон Засгийн газрын бодлогод тодорхой байр суурь эзэлж, үндэсний хэмжээнд конвенцийн заалтуудын хэрэгжилтийг хангах үүднээс шинээр батлагдсан хууль тогтоомжид тусгагдсан.

21. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн дөчин нэгэн зарчим, шаардлагын дагуу хүлээн зөвшөөрөгдсөн, хүүхэдтэй холбоотой нийгмийн бүх харилцааг хууль зүйн хоёр гол эх сурвалжаар Монгол Улсад зохицуулж байна. Үүнд:

- а. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3-ийн дагуу зохицуулагдана.
- б. Конвенцийн заалтууд үндэсний бусад хууль тогтоомжид тусгагдаж, түүний дагуу зохицуулагдаж байна.

Эхний сурвалжийн хувьд Хүүхдийн эрхийн тухай конвенцийн заалтыг нийгмийн бүх гишүүд, төр, түүнчлэн олон нийтийн байгууллагууд хэрэгжүүлэхээр төдийлөн тусгагдаагүй. Хоёрдугаар сурвалжаар зохицуулагдах зүйлүүд нь бүрэн бөгөөд бүрэн бөгөөд зохистойгоор зохицуулагдаж чадаагүй. Эдгээр бэрхшээлүүдийн улмаас хүүхдийн

эрхийн зөрчил ихсэх хандлагатай байна. Иймээс Монголын одоогийн нөхцөл байдал болон үндэсний хууль тогтоомжид конвенцийн заалтууд хангалтгүй тусгагдсаныг харгалзан Хүүхдийн эрхийн тухай конвенцийг хэрэгжүүлэх, хүүхдийн эрхийг хамгаалах иж бүрэн хууль боловсруулах шаардлагатай байна. Үүнд үндэслэн хуулийн төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн бариад байна.

22. Хүүхдийн талаар төр, Засгийн газрын зүгээс дараах үндсэн баримт бичиг болон хуулиудыг боловсруулсан.

### **Төрөөс хүүхэд, залуучуудын талаар баримтлах чиглэл**

23. Энэхүү чиглэл нь 1991 оны 6 дугаар сарын 27-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн 119 дүгээр зарлигаар батлагдсан. Энэхүү баримт бичигт өсвөр, залуу үеэ эрүүл чийрэг өсгөн бойжуулж, эрдэм боловсрол эзэмшүүлэх, эх орноо хөгжүүлэх чин эрмэлзэл, үндэсний эв нэгдэл, хүнлэг энэрэнгүй үзлээр хүмүүжүүлж, Монгол зан заншил, үндэсний уламжлалыг өвлүүлэх, бие дааж аж төрөх нөхцөлийг хангах нийгэм, эдийн засаг, улс төр, эрх зүйн баталгааг бий болгоход төрийн бодлого чиглэгдэнэ гэж заасан.

Энэхүү чиглэлийн агуулга нь хүнд чиглэсэн буюу хүн төвтэй бөгөөд хувь хүнийг хөгжүүлэх талаарх дэвшүүлсэн зорилго нь нийгмийн болон улс төрийн ардчилалтай нягт уялдаа холбоотой хэрэгжинэ.

### **Монгол Улсын Үндсэн хууль**

24. 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан шинэ Үндсэн хууль нь өмнөх Үндсэн хуультай харьцуулахад хүний эрхийг шинэ түвшинд гаргаж дээдэлсэн давуу талтай. Хүүхдийн эрхийн тухай конвенцид тусгагдсан хүүхдийн үндсэн эрхүүд Үндсэн хуулийн 2 дугаар бүлэг буюу хүний эрх, эрх чөлөө гэсэн бүлэгт бүрэн тусгагдсан. Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 11-д “Гэр бүл, эх нялхас, хүүхдийн эрх ашгийг төр хамгаална” гэж заасан. Түүнчлэн 17 дугаар зүйлийн 2-т “Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөж хүмүүжүүлэх ... нь иргэн бүрийн журамт үүрэг мөн” гэж заасан. Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасан. Иймээс Хүүхдийн эрхийн тухай конвенц нь бусад үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ. Үндсэн хуулийн эдгээр бүх заалтууд нь Хүүхдийн эрхийн тухай конвенцийн заалтууд үндэсний хууль тогтоомжид тусгагдах болон шинэ хууль боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах хууль зүйн үндэс нь юм.

### **Хүүхдийг хөгжүүлэх талаар 2000 он хүртэл баримтлах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр (ҮАҮХ)**

25. “Засгийн газар хүнд чиглэсэн буюу хүн төвтэй төсөл болон хүүхдийн эсэн мэнд өсөж бойжих нөхцлийг хангах, хамгаалах, хөгжүүлэх тухай дэлхий дахины Тунхаглалын

дагуу үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээ авна”. Хүүхдийг хөгжүүлэх талаар 2000 он хүртэл баримтлах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийг холбогдох яамд боловсруулж, 1993 оны 5дугаар сарын 27–ны өдөр Засгийн газрын тогтоолоор батлагдсан. Хөтөлбөр хэрэгжилтийн шатандаа явж байна. Үндэсний хөтөлбөрийн хүрээнд, НҮБ–ын Хүүхдийн сантай хамтран хүүхдийн эрүүг мэнд, боловсрол болон нийгмийн бусад салбарт 12 төсөл хэрэгжих гэж байна.

26. Хөтөлбөр өндөр настан, ядуу, тахир дутуу болон өнчин хүүхдүүдийн нийгмийн халамжийг өргөтгөх зорилгыг агуулсан. Одоогийн байдлаар 287 хүүхэд асрамжийн төвд байгаа бөгөөд Засгийн газар жил болгон улсын төсвөөс 60 сая төгрөгийг өнчин хүүхдүүдэд зориулж байна. Улсын төсвөөс 125.5 сая төгрөгийг Тусламжийн санд оруулж хүүхдүүдэд хувцас авч өгөх, 55.7 сая төгрөгийг ядуу өрхийн болон өнчин, тахир дутуу, оюун ухааны хомсдолтой 176,000 гаруй хүүхдэд хувцас авахад зарцуулсан байна. Бараг бүх аймгуудад олон нийтийн тусламжтайгаар “Хүүхдийн халамжийн сан”–г байгуулсан бөгөөд энэ нь өнчин хүүхдүүдэд туслахад олон нийтийн анхаарлыг хандуулахад ихээхэн нөлөөлсөн.

27. Мөн хөтөлбөрт Засгийн газрын зүгээс ам бүл олон бөгөөд бага орлоготой өрхийн хүүхдүүдэд сурах бичиг, хичээлийн хэрэгсэл худалдан авахад хөнгөлөлт үзүүлэх болон цэцэрлэг, зуны амралтын зардлыг төлөх талаар зорилт дэвшүүлсэн. 1993 онд Засгийн газар олон улсын хүүхдийн амралтын төвд 75 сая төгрөг, 18 аймаг, Дархан болон Эрдэнэт хотууд дахь хүүхдийн 22 зуны зусланд 60.6 сая төгрөг, Улаанбаатар хот дахь 13 зуны зусланд 47.1 сая төгрөг болон яамдын харьяа 3 хүүхдийн зусланд 10.7 сая төгрөгийг тус тус зарцуулсан. 1993 онд улсын төсвөөс хүүхдийн зуны зусланд 193.4 сая төгрөгийг зарцуулсан байна. Засгийн газар цэцэрлэгүүдийн хоол хүнсний зардлын 50 хувийг хариуцаж, 1993 онд 2,116,3 сая төгрөгийг энэ зорилгоор зарцуулсан.

28. НҮБ–ын Хүүхдийн сан 1965 оноос хойш Монгол Улстай хамтран ажиллаж, энэ хугацаанд Монголд туслах зорилгоор 1 саяас илүү америк долларыг зарцуулсан. 1996 оны 1 дүгээр сарын 31–нийг хүртэл хугацаан дахь хамтын ажиллагааны шинэ хөтөлбөр батлагдсан. Энэ хөтөлбөр нь үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийн дунд хугацааны зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой.

29. Хөтөлбөрийн хүрээнд 12 төсөл хэрэгжүүлнэ. Эдгээрийн дөрөв нь хүүхдийн эрүүл мэнд, гурав нь хоол тэжээл, хоёр нь суурь боловсрол, хоёр нь хүнд нөхцөл дэх хүүхэд, нэг нь үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр болон Хүүхдийн эрхийн тухай конвенцтой холбоотой. Шинэ хөтөлбөрийг батлахаас өмнө НҮБ–ын Хүүхдийн сангийн дэмжлэг нь голчлон хүүхдийн эрүүл мэнд болон хоол тэжээлтэй холбоотой төслүүдийг санхүүжүүлэхэд зарцуулагдаж байсан.

30. ҮАҮХ–т тусгагдсан 7 гол зорилгын 4 нь хүүхдийн эрүүл мэндтэй холбоотой. Эдгээрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийв.

- а. Нярайн эндэгдлийн бууралт. 1992 онд 1000 амьд төрөлт тутамд 62 нярайн эндэгдэл байсан. 1995 онд дэвшүүлсэн зорилго 59 болгох, 2000 онд 49 болгох явдал юм. Энэ хугацаанд 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 82 байсан ба үүнийг 1995 онд 73 болгох, 2000 онд 61 болгох зорилготой. 1993 онд нярай хүүхдийн эндэгдэл 1,000 амьд төрөлт тутамд 57.4, тав хүртэлх насны хүүхдийн

эндэгдэл 82.7 байсан. Энэ нь урьд онтой харьцуулахад нярайн эндэгдэл 2.6 хувиар буурч, харин 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 0.7 хувиар ихэссэн байна. Нярайн эндэгдэл 1,000 амьд төрөлт тутамд ҮАҮХ-г тусгагдсан доод түвшнээс (1991 он) 4.6 хувь буурч, 1995 оны зорилго 1.6 хувиар биелэгдсэн. Харин 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл доод түвшнээс 0.7 хувиар ихэссэн. Өөрөөр хэлбэл 1991 онд 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1,000 амьд төрөлт тутамд 82,1993 онд 82.7 болж өссөн. Үүний зонхилох гол шалтгаан нь ходоод гэдэсний өвчнүүд, амьсгалын хурц болон бусад халдварт өвчнүүдийн тоо ихэссэнтэй холбоотой. Эдгээрт нөлөөлж буй гол хүчин зүйлүүдэд шаардлага хангахгүй эрүүл ахуйн орчин, үйлчилгээний хангамж байхгүй, бохир, ундны ус болон эхийн эрүүл мэндийн байдал, мөн хоол хүнсний хомсдол болон өрхийн амьжиргааны түвшин доогуур болон бусад олон шалтгаанууд орно.

- б. Эхийн эрүүл мэнд. Эхийн эрүүл мэндийг хамгаалах салбарт хэрэгжиж буй төслүүдийн үр дүнд эхчүүдийн 90-ээс дээш хувь нь амаржсаны дараах асрамжид хамрагдаж, эхчүүд, жирэмсэн эмэгтэйчүүд болон нярай хүүхдүүдийн 95 орчим хувь нь дархлаажуулагдсан. Гэсэн хэдий ч эхийн эндэгдэл 100,000 амьд төрөлт тутамд 30 байгаа нь өндөр хэвээр байна.
- в. Хоол хүнс ба тэжээл. Есөн аймаг, хотуудад хийсэн судалгаанаас харахад дэвшүүлсэн зорилтод хүрсэн амжилт гарсан байна. Өөрөөр хэлбэл, эдгээр нутаг дэвсгэрт 5 хүртэлх насны тэжээлийн дутагдалтай хүүхдийн тоо 13–11.5 хүртэл буурчээ. Хэрэгжиж буй 4 төслийн хүрээнд судалгаа хийх, сургалт явуулах, боловсрол олгох болон тоног төхөөрөмж өгөх хэд хэдэн ажил төлөвлөгдсөн. Одоогийн байдлаар ҮАҮХ-ийг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс хөрөнгө мөнгө зарцуулагдаагүй байна.

### Төвлөрлийг сааруулах

31. Монгол Улс ҮАҮХ-ийг хэрэгжүүлэхдээ үл төвлөрлийн бодлогыг баримталж байна. Энэ зорилгоор дараах 2 чиглэлээр арга хэмжээнүүдийг авч байна.

- а. Аймаг, хот бүр өөрийн бие даасан бодлогыг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- б. Зарим газруудад хүүхдэд чиглэсэн тусгай хөтөлбөр байна. Одоогийн байдлаар бүх аймаг, хотууд ажлын хэсгээ байгуулсан бөгөөд 14 аймаг, хот хөтөлбөрөө боловсруулсан байна.

32. ҮАҮХ-ийг хэрэгжүүлэх үүднээс эдийн засгийн бүс дээр үндэслэн аймаг, хотууд 5 бүсэд хуваагдсан. Энэхүү зохион байгуулалтын арга хэмжээ нь аймаг, хотуудад тухайн бүсийн хүүхдийн нийтлэг ашиг сонирхлыг хангахад адил зан заншил, уур амьсгал болон эдийн засгийн нөхцөл байдлаа харгалзан хамтран ажиллах боломж олгоно.

33. ҮАҮХ-ийн үл төвлөрлийн талаар 8 удаагийн үндэсний, бүсийн болон орон нутгийн сургалт, семинар зохион байгуулагдсан.

34. Орон нутгийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах санхүүжилтийн асуудал бэрхшээлтэй байна. Монгол Улсын Засгийн газар болон НҮБ-ын Хүүхдийн сан хамтран боловсруулсан энэхүү ҮАҮХ-ийг НҮБ-ын Хүүхдийн сангийн шууд болон дан

санхүүжилтээр хэрэгжинэ гэсэн ерөнхий ойлголттой байна. Үүнтэй холбоотойгоор төслийн эх үүсвэрийн зарцуулалт болон үл төвлөрлийн стратегид зарим өөрчлөлт, зохицуулалт хийх шаардлагатай байна.

35. Хөтөлбөрт тусгагдсан олон зорилтууд санхүүгийн эх үүсвэр байхгүйн улмаас хариуцан хэрэгжүүлэх эзэнгүй үлдэж байна. Жишээлбэл НҮБ-ын Хүүхдийн сангаас 1997 он хүртэл тодорхой төлөвлөсөн санхүүгийн эх үүсвэр байхгүйн улмаас эрүүл ахуйн болон усны хангамжийн талаархи асуудлууд хөтөлбөрт тусгагдаагүй. Нөгөө талаар энэ нь уг асуудлыг хариуцсан үндэсний байгууллагууд байхгүйтэй холбоотой.

36. Түүнчлэн ундны усны асуудал Монгол Улсын зүүн болон өмнөд хэсэгт хурцадмал байна. Одоогийн байдлаар зүүн бүсийн зарим хэсэгт нэг хүнд өдөрт дунджаар зөвхөн 8 литр ундны ус ноогдож байна. Харамсалтай нь усны чанар эрүүл ахуйн шаардлага хангахгүй байна. Сүхбаатар аймагт ундны усыг 200 метрийн гүн худгаас авч байна. Тэдэнд түүнээс гүн ухах багаж хэрэгсэл байхгүй байна.

37. Бохир ус хэрэглэснээс хүүхдүүдийн дунд төрөл бүрийн халдварт өвчин тархах бодит аюул байгаа нь тодорхой байна. Гэвч энэ талаар судалгаанд түшиглэсэн шинжлэх ухааны үнэлэлт, дүгнэлт байхгүй байна.

38. Энэхүү нөхцөл байдлыг харгалзан ҮАҮХ-г орон нутгийн Засаг дарга энэ асуудлыг хариуцахаар заасан. Үүний дагуу бие даасан хөтөлбөр, төслүүд хийгдсэн. Харамсалтай нь санхүүгийн болон техникийн эх үүсвэр хангалтгүйгээс амжилттай хэрэгжих боломж хомс байна.

39. ҮАҮХ-ийг хэрэгжүүлэхэд дараах ажлуудыг хийх шаардлагатай байна.

а. ҮАҮХ-ийн хэрэгжилтийн гол бодлого нь орон нутгийн онцгой нөхцөл байдлыг харгалзан тодорхой төсөл, хөтөлбөрөөр дамжуулж үл төвлөрөл дээр тулгуурлаж байна. Энэ зорилгоор бүх аймгуудыг эдийн засгийн чадавхи болон хүүхдийн нөхцөл байдлыг нь харгалзан бүсүүдэд хуваана. Бүс болгонд салбаруудын төлөөллийг оролцуулсан зөвлөлдөх баг байна. Хөтөлбөрийг аймаг, орон нутаг болон үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх мэргэжлийн боловсон хүчин бэлтгэгдэнэ. Үүнтэй холбоотойгоор орон нутгийн хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд арга зүйн туслалцаа үзүүлэх эрчимтэй үйл ажиллагааг зохион байгуулах.

б. 1994 оны 12 дугаар сарын 1-нээс өмнө ҮАҮХ-ийн хэрэгжилтийг аймаг, орон нутгийн түвшинд шалгах хяналтыг зохистой бий болгож, бүх аймаг, хотуудаас цуглуулсан мэдээллийн үндсэн дээр жил болгон түүний хэрэгжилтийг дүгнэнэ.

в. Сангийн яам болон Үндэсний хөгжлийн газартай хамтран улсын жилийн төсвөөс ҮАҮХ-ийн хэрэгжилтийг хангах санхүүжилтийг гаргах талаар Засгийн газрын тогтоол батлуулах

г. Салбар хоорондын ажлын хэсгийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, мөн хүүхдийн ашиг сонирхлын төлөө нийтийн хүчин чадлыг дайчлах механизмыг бүрдүүлэх. Энэ зорилгоор төрийн бус байгууллагууд, хувийн хэвшлийн оролцоо туслалцааг хангах хүүхдийн хамгаалал, эрх ашгийг хариуцсан Үндэсний хороо байгуулах шаардлагатай байна.

д. ҮАҮХ-ийн хэрэгжилтийг хангахад НҮБ-ын Хүүхдийн сангаас гаргаж буй эх үүсвэрийг үр дүнтэй, ашигтай зарцуулахад онцгой анхаарал хандуулах. Энэ зорилгоор

НҮБ–ын Хүүхдийн сангаас санхүүжиж буй төслийн менежерүүдэд үйл ажиллагааны үр дүнг дээшлэх үүднээс семинар зохион байгуулах.

е. Засгийн газартай байгуулсан гэрээний үндсэн дээр төсөл хэрэгжүүлж буй олон улсын байгууллагууд, донор орнууд болон хандивлагчидын үйл ажиллагааг нь хүүхдийн эрх ашигт нийцсэн үйл ажиллагаанд чиглүүлэх, тэдгээртэй хамтран ажиллах зөвлөлдөх уулзалт зохион байгуулах

### **Б. Үндэсний хууль тогтоомжид хүүхдийн эрхийн тусгагдсан байдал**

40. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд (Улсын Их Хурлаас 1993 онд батлагдсан) 16 хүртэлх насны хүүхэд бүр (ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа бол 18 нас хүртэлх) эрүүл мэндийн даатгалд заавал даатгуулах бөгөөд даатгалын шимтгэлийг төрөөс хариуцахаар заасан.

41. Боловсролын тухай хуульд (1991 оны 7 дугаар сарын 16–ны өдөр батлагдсан) иргэд 17 нас хүртлээ суурь боловсрол эзэмших бөгөөд сургалтын төлбөрийг төрөөс хариуцахаар заасан. Түүнчлэн сургуулийн дотуур байрны зардал, сургуулиас хол амьдардаг хүүхдүүдийг гэр болон сургууль хооронд ирж очих зардлыг жилд нэг удаа төрөөс хариуцахаар заасан.

42. Хөдөлмөрийн тухай хуулиар (1991 оны 2 дугаар сарын 14–ны өдөр батлагдсан) насанд хүрээгүй хүүхдийг ажиллуулахыг хориглосон ажлын жагсаалтыг гаргаж, хөдөлмөр эрхлэх насны доод хэмжээ, хөдөлмөрийн нөхцөл, цалин, ажлын цаг болон хүүхдэд хөдөлмөр, мэргэжил олгох асуудлыг зохицуулсан. Хөдөлмөр эрхлэх насны доод хэмжээ 15 нас ба хөдөлмөр эрхэлж буй насанд хүрээгүй хүүхэд эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамрагдах ёстой.

43. Тэтгэврийн тухай хуульд (1990 оны 12 дугаар сарын 10–ны өдөр батлагдсан) хагас болон бүтэн өнчин хүүхэд тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрхтэй гэж заасан. Тэтгэврийн хэмжээ нь нас барагчийн хөдөлмөрийн орлого, эзэмшил, үхлийн шалтгаанаас хамаарах ба доод хэмжээг хуулиар тогтоосон.

44. Тэтгэмжийн тухай хууль (1991 оны 4 дүгээр сарын 15–ны өдөр батлагдсан) янз бүрийн шалтгаан, нөхцөлтэй хүүхдэд олгох (нярайн, олон хүүхэдтэй өрх, ихрүүд гэх мэт) тэтгэмжийг ангилж, тэтгэмж тус бүрийн хэмжээг тогтоосон.

45. Иргэний хууль (1963 онд батлагдсан) хүүхдийн иргэний эрх зүйн хэсэгчилсэн чадамж, түүнтэй холбогдох арга хэмжээг тогтоосон. Хуульд хүүхэд иргэний хэрэгт эцэг, эхээрээ төлөөлүүлэн оролцоно гэж заасан.

46. Эрүүгийн хууль (1986 оны 5 дугаар сард батлагдсан) 14–өөс дээш насны хүүхэд гэмт хэрэг үйлдсэний төлөө эрүүгийн хариуцлага хүлээх тухай заасан боловч тухайн хүүхэд 18 насанд хүрээгүй бол цаазаар авах ял оногдуулахгүй гэж заасан, Эрүүгийн хууль хүүхдийн эрхийн зөрчлийг гэмт хэрэгт тооцож, гэмт хэрэгтэнд эрүүгийн хариуцлага ногдуулахаар заасан. Жишээ нь хүүхдийг гэмт үйл ажиллагаа, садар самуун, хар тамхинд татан оролцуулах, хүүхдийн тэтгэвэр төлөхөөс зайлсхийх, хүүхдийг зориуд хаях, төөрөгдүүлэх болон хулгайлах, хүүхдийг аюултай нөхцөлд орхих, байнга зодох, бие махбодийг тарчлаан зовоох нь уг хуулийн дагуу гэмт хэрэгт тооцогддог.



47. Гэр бүлийн тухай хуулиар (1973 оны 7 дугаар сарын 16–ны өдөр батлагдсан) гэрлэх насны доод хэмжээг 18 насаар тогтоосон. Эцэг, эхчүүд үр хүүхдээ эрүүл чийрэг өсгөж бойжуулах, ажилч хичээнгүй, шударга иргэн болгох, тэдэнд суурь боловсрол эзэмшүүлэх үүрэг хүлээсэн. Хуульд зааснаар эцэг, эхийн үүрэг бол хүүхдийн ашиг сонирхлыг дээд зэргээр хамгаалах явдал юм гэж заасан. Мөн уг хуулиар эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах болон үрчлэхтэй холбоотой журмыг зохицуулсан (гадаадын иргэдэд хүүхэд үрчлэх асуудлыг нарийвчлан зохицуулаагүй).

48. Эрүүгийн байцаан шийтгэх хууль (1994 оны 3 дугаар сард батлагдсан) хүүхдийн эрх зүйн чадамжтай холбоотойгоор хүүхдэд хамгаалалт бий болгосон. Хэн ч хүүхдийг ганцааранг нь байцаах буюу шүүхийн өмнө аваачих эрхгүй. Мөрдөн байцаалтын аль ч үе шатанд хүүхэд өмгөөлөгч, эсвэл эцэг, эх эсвэл, хууль ёсны төлөөлөгчтэй оролцоно. Хүүхэд оролцсон аливаа хэргийн шүүхийн өмнөх шатны мөрдөн байцаалт аль болох богино хугацаанд явагдах ёстой.

## **В. Хүүхдийн талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх механизм**

49. Улсын Их Хурлын Хүн ам, эрүүл мэнд, хөдөлмөр болон нийгмийн асуудал эрхэлсэн байнгын хороо нь хүн амын талаарх бодлогыг тодорхойлох, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг боловсруулах, хэрэгжилтийг хянахад онцгой үүрэг гүйцэтгэдэг. Одоогийн байдлаар тус хороо Хүүхдийн эрхийг хамгаалах тухай Монгол Улсын хуулийн төсөл дээр ажиллаж байна.

50. Хүн амын бодлого болон хөдөлмөрийн яам 1992 оны 8 дугаар сард байгуулагдсан. Тус яам хүн амын талаарх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг хариуцдаг.

51. Хүүхдийн төлөө үндэсний төв (ХТҮТ) нь 1991 оны 5 дугаар сард Засгийн газрын 151 дүгээр тогтоолоор төрийн хүүхдийн талаарх бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулах, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах үүрэгтэйгээр байгуулагдсан. 1993 оны 2 дугаар сараас хойш ХТҮТ нь дараах үйл ажиллагааг зохион байгуулж ирсэн.

- а. Нийгмийн халамж шаардлагатай хүүхдүүдийг анхаарч, тэдэнд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах
- б. Хүүхдийн эрхийн хамгааллын талаар хүчин төгөлдөр үйлчилж буй үндэсний хууль тогтоомжийг сайжруулах санал боловсруулах, судалгаа хийж, дүгнэлт гаргах
- в. Хүүхдийн эрхийг хамгаалах асуудлаар НҮБ–ын Хүүхдийн сан болон бусад олон улсын, бүсийн болон үндэсний байгууллагуудтай хамтарч ажиллах
- г. Хүүхдийн эрхтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх
- д. Хүүхдийг өөрийнх нь авьяас, сонирхлын дагуу хөгжүүлэх, хүүхэд чөлөөт цагаа зөв, үр дүнтэй өнгөрүүлэх арга хэмжээ зохион байгуулах
- е. Олон нийтийн байгууллагууд болон нийгэмлэгүүдийн санаачилгыг дэмжих, идэвхжүүлэн урамшуулах
- ё. Хүүхдүүд амралтаа үр бүтээлтэй өнгөрүүлэх нөхцлийг хангах болон хүүхдэд зориулсан аялал жуучлал, мэдээлэл харилцааг зохион байгуулах

52. ХТҮТ нь 14 үндсэн ажилтантай. Аймаг, хотуудын хүүхдийн төв 3–5 ажилтантай үйл ажиллагаа явуулдаг. Хүүхдийн асуудал эрхэлсэн зааварлагч сум, дүүрэг болон бүс болгонд ажилладаг. Түүнчлэн ХТҮТ–ийн дэргэд Олон улсын хүүхдийн амралтын төв, Монголын Хүүхдийн ордон, Монголын Хүүхдийн урлан бүтээх төв, Хүүхдийн хэвлэлийн зөвлөл, “Залгамжлагч” хүүхдийн аялал жуулчлалын клуб, “Солонго”, “Есөн эрдэнэ” зэрэг хүүхдийн соёл, спортын төв болон хэд хэдэн зуслан зэрэг хүүхдийг хөгжүүлэх болон тэдгээрийн чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх ажлыг хариуцан зохион байгуулдаг харьяа байгууллагуудтай.

53. ХТҮТ болон түүний орон нутгийн салбарууд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг.

### Г. Конвенцийг олон нийтэд сурталчлах ажил

54. Монгол Улс 1991 онд Хүүхдийн эрхийн тухай конвенцид нэгдэн орсон даруй конвенцийг монгол хэлнээ орчуулж, олон нийтэд зориулан үндэсний сонин хэвлэлүүдэд нийтэлсэн.

55. Үүнээс хойш Хүүхдийн эрхийн тухай конвенц нь хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг хүмүүсийн дагаж мөрдөх гол бичиг баримт болж, тэдгээрийн үйл ажиллагаа конвенцийн заалт бүрийг хэрэгжүүлэхэд чиглэгдэх болсон.

56. Радио, телевиз, хэвлэл зэрэг олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагууд конвенцийн зарчим, заалтуудыг тайлбарлах, хүүхдийн эрх, эрх чөлөөний хэрэгжилт, Монгол Улсад тэдгээр эрхийг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээлүүд болон тэдгээрийг даван туулах арга зам, мөн хүүхдийн эрхийн зөрчлийн талаар өргөн хэмжээний мэдээлэл, нийтлэл, нэвтрүүлэг явуулдаг. Монголын радио болон телевиз Монголын хүүхдүүдэд тулгарч буй хүндрэл бэрхшээлийн талаар тусгай нэвтрүүлэг бэлтгэж нэвтрүүлдэг. Түүнчлэн хөтөлбөрүүд хүүхдийн эрхийг зөрчсөн хэргийг гаргаж тавьдаг.

57. Дараах хүндрэл бэрхшээлүүд тулгарч байна.

- а. Хэдийгээр радио, телевиз болон бусад хэвлэл мэдээллийн байгууллагууд Хүүхдийн эрхийн тухай конвенцийн талаар тусгай нэвтрүүлэг нэвтрүүлдэг ч, хичээлийн хөтөлбөрт хүүхдийн эрхийн талаар тусгайлан бэлтгэсэн материал, сургапт байхгүй байна.
- б. Конвенцийг олон нийтэд ерөнхий байдлаар сурталчилж, хүүхдийн эрхийн талаар олон нийтэд мэдээлж байгаа ч конвенцийн хэрэгжилтийг хангах, хэрэгжилтийн талаарх судалгаа хийх, арга зүйн үүднээс хандах тодорхой механизм байхгүй байна.
- с. Сүүлийн үед эцэг, эхчүүд болон нутгийн захиргааны байгууллагын удирдлагуудад конвенцийн зарчим, заалтуудыг иж бүрнээр ойлгуулах тусгай үйл ажиллагаа зохион байгуулах хэрэгцээ шаардлага бий болж байна.

58. Тиймээс конвенцийг сурталчлан таниулах ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- а. Конвенцийн үзэл санаа бүрттусгай хөтөлбөр боловсруулах, конвенцийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий хүмүүст сургалт зохион байгуулах. Жишээ нь

цагдаа, шүүх, урьдчилан хорих төвийн ажилтнуудад гэмт хэрэгг холбогдсон болон урьдчилан хорих төвүүдэд хоригдож буй хүүхэд эсвэл хаягдсан хүүхдийн эрхийг хамгаалах талаар сургалт зохион байгуулах.

- б. Конвенцийн хэрэгжилтийг үнэлж дүгнэх шалгуур боловсруулах үндэсний хэмжээний механизм бий болгох.

59. Конвенцийг хэрэгжүүлэхэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

60. Төрийн хүүхдийн талаарх бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх болон үйл ажиллагааг нь энэ чиглэлд чиглүүлэх үүрэг бүхий Хүүхдийн төлөө үндэсний төвийг байгуулсан нь Хүүхдийн эрхийн тухай конвенцийг хэрэгжүүлэх болон хүүхдийн ашиг сонирхолд нийцүүлэн нийгмийн асуудлыг шийдвэрлэх олон нийтийн оролцоог нэмэгдүүлж сайжруулсан. Жил болгон ХТҮТ иргэд, байгууллагуудад хүүхдэд боломжоороо үйл ажиллагаагаа зориулахыг уриалж, 6 дугаар сарын 1 буюу олон улсын хүүхдийн эрхийн өдөр энэ хугацаанд зохион байгуулсан үйл ажиллагааны үр дүнг нэгтгэн гаргадаг. Энэхүү ажиллагааны үр дүнд 1993 онд 1990 байгууллага, хувь хүмүүс ХТҮТ болон түүний салбаруудыг дэмжигч болсон. Аймаг, хот болгонд өнчин, ядуу өрхийн болон нийгмийн хамгаалал шаардлагатай хүүхдүүдэд туслах хандивын сан байдаг.

61. Түүнчлэн Засгийн газрын байгууллагууд өөрсдийн салбарын хүрээнд хүүхдүүдэд хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- а. Тээврийн удирдах газар аялал жуулчлал болон зусланд хамрагдаж буй хүүхдүүдийн тээврийн зардалд 50 хувийн хөнгөлөлт үзүүлэх шийдвэр гаргасан.
- б. Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас Хөдөө аж ахуйн хэлтсийн дарга, компани, хоршоо болон аж ахуйн нэгжүүдэд тодорхой үүрэг болгосон хүүхдийн хамгааллын арга хэмжээг баталсан сайдын тушаал гаргасан. Түүнчлэн хөдөөгийн хүүхдийн нийгмийн асуудал, тэдгээрийн хөдөлмөр болон боловсролын асуудлыг тусгасан “Хөдөөгийн хүүхдүүд” тусгай төсөл хэрэгжүүлэх шийдвэр гаргасан.
- в. Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам ажилгүйчүүдийн дунд 8, 10 дугаар анги төгссөн хүүхдүүдийн тоо их байгааг харгалзан тэднийг мэргэжлийн сургалтын төвүүдэд хамруулах, ажлын байр бий болгох арга хэмжээ авсан. Бусад яамдууд эдгээрийн адил хүүхдийн эрх ашигт нийцсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Монголын шашны зөвлөл хаврын сүүлчийн сарын 29-ний өдөр хүүхдийн оюун ухааныг хөгжүүлэх тусгай ном хурахаар шийдвэрлэж, энэ өдрийг хүүхдэд хандив өргөх өдөр болгон, улмаар сүсэгтэн олны өргөсөн өргөлийн тодорхой хэсгийг хүүхдийн халамжийн санд шилжүүлдэг жишиг тогтсон.

## II хэсэг. Хүүхдийн тодорхойлолт

62. Одоогийн байдлаар Монгол Улсад насны доод хэмжээг тогтоож хүүхдийг тодорхойлсон хууль байхгүй. Гэсэн хэдий ч 18 нас хүрээгүй бүх хүнийг хүүхэд гэж ерөнхийд нь ойлгодог. Хүүхдийн эрхтэй холбоотойгоор хууль болгон насны хязгаарыг өөр өөрөөр тогтоосон. Үүнд:

- а. Монгол Улсын Үндсэн хуулийн (1992) 16 дугаар зүйлийн 10–т 18 нас хүрсэн Монгол Улсын иргэн бүр сонгох эрхтэй гэж заасан. Үндсэн хуулийн энэхүү заалт нь 18 нас хүрсэн хэн боловч өөрийн эрхийг эдэлж, үүрэг хүлээх чадвартай гэдгийг харуулж байна.
- б. Иргэний хуулийн (1963 он) 9 дүгээр зүйлд 18 нас хүрсэн Монгол Улсын иргэн шүүхийн өмнө эрх эдэлж, үүрэг хүлээх талаар заасан. Харин тус хуулийн 11 дүгээр зүйлд 15–18 нас хүрсэн хүн өөрт хоргүй бөгөөд хиймэгц, аж амьдралын чанартай жижиг хэлцэл хийх эрх зүйн этгээд байж болох талаар заасан.
- в. Боловсролын тухай хуулийн (1991 он) 4 дүгээр зүйлийн дагуу Монгол Улсын иргэн бүр 17 нас хүртлээ суурь боловсрол эзэмшихээр заасан.
- г. Иргэний цэргийн үүрэгтэн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулиар (1993 он) цэргийн алба хаах насны доод хэмжээг 18 насаар тогтоосон.
- д. Гэр бүлийн тухай хуулийн (1973 он) 9 дүгээр зүйлд гэрлэх насны доод хэмжээг 18 насаар тогтоосон.
- е. Хөдөлмөрийн тухай хуулийн (1991 он) 85 дугаар зүйлд хөдөлмөр эрхлэх насны доод хэмжээг 16 насаар тогтоосон ба 15 настай хүүхдийг эцэг, эх буюу харгалзан дэмжигчийн зөвшөөрөлтэйгөөр тэдгээрийн эрүүл мэнд, хөгжил болон оюун ухааны хөгжилд харшлахгүй ажилд ажиллуулахыг зөвшөөрсөн. Түүнчлэн 14 настай хүүхэд эцэг, эх буюу асран хамгаалагчийн зөвшөөрөлтэйгөөр мэргэжлийн баримжаа, ажлын дадлага олох зорилгоор хөдөлмөр эрхэлж болно. Энэ хуулийн 86 дугаар зүйлд 18 нас хүрээгүй ажилтныг шөнийн цагаар буюу илүү цагаар, түүнчлэн нийтээр амрах баярын болон долоо хоногийн амралтын өдөр ажиллуулахыг хориглосон. Хуулийн 26 дугаар зүйлд 14–15 настай ажилтан долоо хоногт 30 цагаас илүүгүй, 16–18 настай ажилтан 36 цагаас илүүгүй ажиллахаар заасан.
- ё. Эрүүл мэндийн тухай хуулийн (1997 он) 67 дугаар зүйлд 18 насанд хүрээгүй хүүхдийг эрүүл мэндийн үзлэгт хамрагдсаны дараа ажилд авах, ажилд авсны дараа жилд 2–оос доошгүй удаа эрүүл мэндийн үзлэгт хамрагдахыг заасан.
- ж. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн (1993 он) 67 дугаар зүйлд 16 хүртэлх насны хүүхэд бүр (ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа бол 18 нас хүртэлх) эрүүл мэндийн даатгалд заавал даатгуулах бөгөөд даатгалын шимтгэлийг төрөөс хариуцахаар заасан.
- з. Иргэний хуулийн (1967 он) 37 дугаар зүйлийн дагуу 15–18 насны хүүхэд шүүхийн өмнө бие даан өөрийнхөө эрхийг хамгаалах эрхтэй гэж заасан. 138 дугаар зүйлд шүүх 16 нас хүрээгүй гэрчид зөвхөн үнэн зөв мэдүүлэг өгөх ёстойг анхааруулах ба харин худал мэдүүлэг өгсний төлөө хүлээх хариуцлагын талаар сануулахгүй байхыг заасан.
- и. Эрүүгийн хуулийн (1986 он) 9 дүгээр зүйлд 14–өөс дээш насны хүүхэд эрүүгийн хэрэгт шүүхийн өмнө эрүүгийн хариуцлага хүлээхээр заасан. Хуулийн 22 дугаар зүйлийн дагуу 18 нас хүрээгүй хүүхдэд оногдуулах хорих ялын дээд хэмжээ 10 жилээс дээшгүй байна.

63. Дээрх хуулиуд хүүхдийн насны байдлаас хамааран тодорхой эрхүүдийг олгожээ. Гэвч практикт эдгээр заалтуудын хэрэгжилт зөрчигдөх тохиолдол их байна. Жишээ нь хуульд хөдөлмөр эрхлэх насны доод хэмжээг 16, онцгой тохиолдолд 14 байхаар заасан. Гэвч амьдралын нөхцөл байдлаас шалтгаалж хүүхдүүд бага наснаас эхлэн ажил хийдэг. Хуульд зааснаар зөвхөн 14 нас хүрсэн хүүхэд үйлдсэн хэрэгтээ хариуцлага хүлээхээр заасан. Гэвч практикт 14-өөс доош насны хүүхэд гэмт хэрэгт холбогддог. Энэ тохиолдолд уг асуудлыг шийдвэрлэх хууль тогтоомж байхгүй. Иймээс асуудлыг шийдвэрлэх болон хүүхдийн талаарх нэгдсэн тодорхойлолтыг тусгасан зохистой хууль боловсруулж, хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлагыг бий болгож байна.

### **III хэсэг. Ерөнхий зарчмууд**

#### **A. Үл ялгаварлан гадуурхах**

##### **2 дугаар зүйл**

64. Монгол Улсын Үндсэн хуулийн (1992) 14 дүгээр зүйлд “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”

“Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.” гэж заасан.

65. Монгол Улсад эмэгтэйчүүд, хөдөөгийн хүүхэд болон цөөнхийн хүүхдийг ялгаварлан гадуурхсан практик байхгүй. Харин өнчин хүүхэд, тахир дутуу хүүхэд болон асран хамгаалагчгүй хүүхдэд эрхээ эдлэхэд нь туслах арга хэмжээнүүдийг авч байна. 1993 оны байдлаар Монгол Улсад 0–16 насны 4,427 бүтэн өнчин, 54,674 хагас өнчин хүүхэд байсан. Мөн 1,000 гаруй хүүхэд гэр бүл, асран хамгаалагчгүй бөгөөд төмөр замын дагуу тогтмол амьдардаг гэж бүртгэгдсэн байна. Мөн 3,949 тахир дутуу, 17,198 оюун ухааны хомсдолтой хүүхэд байна.

66. Эдгээр хүүхдүүдийн зарим нь асрамжийн газар амьдрах, тусгай сургуульд сурах зэрэг хангамжаар хангагдсан. Энэ чиглэлээр тодорхой арга хэмжээ дэвшүүлж хэрэгжилтийн шатандаа явж байна. Улаанбаатар хотод 270 хүүхэдтэй асрамжийн газар үйл ажиллагаа явуулж байна. Аймаг, орон нутгийн түвшинд эдгээр хүүхдүүдэд байгаа нөөц бололцоондоо тулгуурлан туслах арга хэмжээ авч байна. Тахир дутуу хүүхдүүдийг сургах тусгай хөтөлбөр бүхий сургалтын систем үйлчилж байна. Улсын хэмжээнд нийт тахир дутуу болон оюун ухааны хомсдолтой хүүхдүүдийн 20 хувийг хамарсан 15 тусгай сургууль байна. Улаанбаатар хотод орон гэргүй тэнэмэл хүүхдүүдийг асрах нэг төв ажиллаж байна. Энэ төв нь доод тал нь 60–100 хүүхдэд тогтмол үйлчилж байна.

67. Өнчин, тахир дутуу, ядуу өрхийн хүүхэд болон асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй хүүхдүүдэд туслах үйл ажиллагаа нь тэдгээр хүүхдүүдийг хоол хүнс, хувцсаар тогтмол хангах хэлбэрээр явагдаж байна.

68. Эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд учирч буй гол бэрхшээл бол санхүүгийн бэрхшээл юм. Энэхүү шилжилтийн үед тус улсад тулгарч буй эдийн засгийн хямралаас хамаарч төрөөс нийгмийн энэхүү эмзэг бүлэгт чиглэсэн бүх зардлыг хариуцах эсвэл

үйл ажиллагааг тэтгэх, санхүүжүүлэх боломжгүй байна. Иймээс энэ чиглэлд олон нийт, аж ахуйн нэгжийн хүчийг дайчлах, өрхийн үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх чадавхийг дээшлүүлэхэд гол анхаарлаа хандуулж байна.

## **Б. Хүүхдийн эрх ашгийг дээд зэргээр хангах**

### **3 дугаар зүйл**

69. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 11–д “гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж заасан. Энэ бол төрийн зүгээс хүүхдийн эрх ашгийг дээд зэргээр хангах хууль зүйн баталгаа юм. Монгол Улсад хүүхдийн эрх ашгийг дээд зэргээр хангах асуудлыг шууд зохицуулсан хууль байхгүй. Гэвч энэ санааг тусгасан, хүүхдэд хүнлэг ёсоор хандсан, хүүхэдтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх хуулийн заалтууд үйлчилж байна.

70. Хүүхдийн төлөө үндэсний төв нь 1991 онд хүүхдийн эрх ашгийг хангах, хамгаалах зорилгоор байгуулагдсан. ХТҮТ–ийн үйл ажиллагааны гол зорилго нь хүүхдийн эрх ашгийг дээд зэргээр хангах зарчимд үндэслэсэн. Түүний үйл ажиллагаа нь олон нийтийн анхаарал, үйл ажиллагааг хүүхдэд хандуулахад чиглэгддэг. Үүний үр дүнд өнөөдөр хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг бүх байгууллагын үйл ажиллагаа төрөөс санхүүждэг. Энэхүү зарчмыг хэрэгжүүлэхэд тулгарч буй гол бэрхшээл санхүүгийн бэрхшээл юм. Санхүүжилттэй холбоотой нэгдсэн хууль, дүрэм үйлчилдэггүй. Эдийн засгийн хямралаас хамаарч жил бүр санхүүгийн эх үүсвэр буурч байна. Зах зээлийн эдийн засгийн зарчмын дагуу хүүхдийн байгууллагууд өөрсдөө бие даан санхүүжих шаардлагатай тулгарч байна.

## **В. Амьд мэнд, эрүүл саруул өсөж торних**

### **6 дугаар зүйл**

71. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд амьд явах эрхийг баталгаажуулсан. Гагцхүү онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь насыг бусниулахыг хатуу хориглосон. Харин 1983 оны Эрүүгийн хуульд арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээдэд цаазаар авах ял оногдуулж болохгүй гэж заасан.

72. Эрүүл мэндийн тухай хуульд (1977 он) Монгол Улсын эрүүл мэндийн бодлогын гол зорилго нь хүүхэд, эхчүүдийн эрүүл мэндийн байдлыг сайжруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад оршино гэж заасан. Хуулийн заалтууд төрийн бүх байгууллагууд болон олон нийтийн байгууллагуудын үүрэг бол эрүүл, саруул хүүхдийг хөгжүүлэх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, тэдгээрийн оюун ухааны болон бие бялдрын өв тэгш хөгжлийг хангах нөхцөлийг бүрдүүлэх гэж заасан. Уг хуульд эх нялхас, хүүхдийг хамгаалах талаар тусгай заалт байдаг. Энэ заалт нь хүүхдийг хамгаалах талаарх арга хэмжээнүүдийг дэлгэрэнгүй тодорхойлсон.

73. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль (1993) төрийн зардлаар 16 насанд хүрээгүй хүүхэд бүр (ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа бол 18 нас

хүртэл) эрүүл мэндийн даатгалд хамрагдахаар заасан. Түүнчлэн хуулийн заалтууд төрөхийн өмнөх халамж болон хүүхэд өсөж бойжих таатай орчинтой холбоотой асуудлыг зохицуулж өгсөн. Уг хуулийн хүрээнд холбогдох яамд үүнтэй холбоотой дүрэм, журмыг боловсруулсан. Жишээ нь 6 сараас 1 нас хүртэлх хүүхэдтэй эхчүүд, жирэмсэн эмэгтэйчүүдэд холбогдох дүрэм, түүнчлэн төрөөс 3 болон 4 ихэр хүүхдийн хувьд тодорхой хариуцлага хүлээх дүрэм үйлчилж байна.

74. Боловсролын тогтолцоо нь дараах бүтцүүдэд хуваагддаг. 3–4 настай хүүхэд тэдгээрийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон боловсрол олгох сургуулийн өмнөх насны хүүхдийн цэцэрлэгт хамрагддаг. Ерөнхий боловсролын сургууль бол сурч боловсрох эрхийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн сургалтын тогтолцооны гол цөм юм. Бид сургалтын хөтөлбөр нь хүүхдэд иж бүрэн боловсрол, мэдлэг олгоход хангалтгүй гэж үзсэн. Иймээс хэд хэдэн байгууллагууд энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ хүүхдийг гэр бүлийн орчинд хөгжүүлэх бодлого баримталж байна. Энэ бодлогын хүрээнд “Хүүхдийг гэр бүлийн хүрээнд хөгжүүлэх хөтөлбөр” болон “Өв уламжлал хөтөлбөр” зэрэг төслийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

75. Эдгээр эрхүүдийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээнүүд.

- а. Хүүхдийн эрүүл мэнд, боловсрол болон нийгмийн хамгааллыг хангалттай түвшинд хүрсэн тохиолдолд тогтвортой хадгалах арга хэмжээ авч, эдгээртэй холбоотой зардлыг төр хариуцаж байна;
- б. Их, дээд сургуулиудад хүүхэдтэй ажилладаг багш, эмч зэрэг боловсон хүчнийг бэлтгэж байна;
- в. Амьд явах, хөгжих эрхийг хангахад чиглэсэн үндэсний хөтөлбөр боловсруулж байна.

76. Учирч буй бэрхшээлүүд;

- а. Зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд хүүхдийг хөгжүүлэхэд чиглэсэн нийгмийн хүчин чармайлтыг дайчлан ашиглах тогтсон удирдамж алга;
- б. Хүүхдийг хөгжүүлэх гэр бүлийн үүрэг хариуцлагыг орхигдуулж төр бүх хариуцлагыг хүлээх хуучин муу хандлага бат бөх оршсоор байна;
- в. Дэвшүүлсэн зорилгыг хэрэгжүүлэхэд тулгарч буй гол бэрхшээл бол эдийн засгийн буюу санхүүгийн эх үүсвэрийн хомсдол байна.

77. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ;

- а. Ойрын хугацаанд хүүхдийн амьд явах болон хөгжих эрхийн талаар дээд түвшний үндэсний зөвлөлдөх хурлыг зохион байгуулах;
- б. Хүүхдийн эрхийг хамгаалах үндэсний хууль батлах. Хүүхдийн хөгжлийг хангахад хувийн секторын оролцоог дээшлүүлэх эрчимтэй бодлого боловсруулах,

## Г. Хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх

### 12 дугаар зүйл

78. Энэхүү эрхийн хэрэгжилтийг хангах үзэл баримтлал нь хүүхэдтэй ойр дотно ажилладаг багш нарын бэлтгэлтэй нягт холбогддог. Их сургуулиуд болон бусад дээд

мэргэжил олгох институтийн хамгийн чухал үүрэг бол багш нарыг бэлтгэх явдал юм. Одоогийн байдлаар мэргэшсэн багш нарыг бэлтгэдэг Улсын багшийн их сургууль, бага ангийн болон цэцэрлэгийн багш нарыг бэлтгэдэг багш нарын коллеж байна. Түүнчлэн багш нарын мэргэжил дээшлүүлэх институт ажиллаж байна.

79. Боловсролын тухай хуульд багш нарыг бэлтгэх болон дахин сургах тухай тусгай заалт үйлчилдэг. Хүүхдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн талаарх эцэг, эхийн үүрэг ролийн чухлыг анхаарч Монголын радио эцэг, эхчүүдэд зориулсан “Эцэг, эхийн боловсрол” зэрэг хэд хэдэн тусгай хөтөлбөрийг нэвтрүүлсэн ба мөн энэ сэдвээр олон нийтлэлүүд хэвлэл мэдээлэлд нийтэлсэн.

80. Конвенцийн энэхүү заалтыг хэрэгжүүлэхэд хүүхдийн нийгмийн амьдралд оролцох оролцооны чухлыг анхаарч тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Эдгээр үйл ажиллагаануудыг ихэвчлэн жилийн эхэнд төлөвлөж, шаардлагатай санхүүгийн асуудлуудыг урьдчилан шийдвэрлэдэг. Энэ зорилтын хүрээнд ойролцоогоор 30-аад үйл ажиллагаа уламжлалт арга хэмжээ болоод байна. Эдгээрт жишээ нь хүүхдэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж олгодог уралдаан, хурал, уулзалт ярилцлага орно. Түүнчлэн идэвхтэй оролцсон хүүхдүүдийг шагнаж урамшуулах тогтолцоо үйлчилдэг. Хүүхдийн сонин, радио телевиз нь хүүхдийн үзэл бодлоо чөлөөтэй, нээлттэй илэрхийлэх эрхийг хүндэтгэхэд зориулсан тусгай хөтөлбөрүүдийг явуулж байна. Эдгээр хөтөлбөрүүдийн хүрээнд Хүүхдийн утас, Улаан шугам, Хүүхдийн үг зэрэг үйл ажиллагаанууд зохион байгуулагдсан. Ийм төрлийн үйл ажиллагаанууд уламжлал болон хөгжсөн.

81. Хүүхдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь Монгол Улсын хууль тогтоомжид тодорхой тусгагдсан. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16-д “үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрхийг баталгаажуулсан. Эдгээр суурь эрхүүд хүүхдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хууль зүйн баталгаа юм. Үндсэн хуулийн энэ заалт Монгол Улсын бусад хууль тогтоомжид тусгалаа олсон. Гэр бүлийн тухай хуульд эцэг, эх нь салж байгаа тохиолдолд хүүхэд өөрийн хууль ёсны асран хамгаалагчийн талаар шүүхэд саналаа хэлэх эрхтэй гэж заасан. Өөрөөр хэлбэл есөөс дээш насны хүүхдийн санал бодлыг харгалзан үзнэ гэсэн үг. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хэн ч хүүхдийг шүүхийн өмнө ганцааранг нь аваачин байцааж болохгүй бөгөөд хүүхэд өмгөөлөгч эсвэл хууль ёсны төлөөлөгчтэй хамт байлцах, шүүх хүүхэдтэй холбоотой хэргийг хаалттай явуулахаар заасан.

82. Нөлөөлж буй хүчин зүйлүүд болон бэрхшээлүүд.

- а. Зарчмын хувьд хүүхэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх таатай орчин бүрдсэн. Гэвч бидэнд гэр бүл дэх хүүхэд бүрийн нөхцөл байдлыг тодорхойлж, хүүхэд бүрт хүрч ажиллах зохистой арга дутагдаж байна;
- б. Гарч буй нөхцөл байдалд хүүхдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд туслах багш, эцэг, эхчүүдэд зориулсан сургалт одоо хүртэл байхгүй байна;
- в. Хүүхдийн асуудлаар мэргэшсэн хуульч, социологич эсвэл бусад мэргэшсэн хүмүүсийг сургах тогтолцоо байхгүй байна;
- г. Хүүхдийн асуудлыг зохицуулж буй ихэнх журмууд нь өөрчлөгдөж буй нөхцөл байдалд нийцэхгүй байна;
- д. Хүүхдийн үзэл бодлыг судлах, дүгнэх байгууллага байхгүй байна.



83. Хийх ажлууд:

- а. Хүүхдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эрхийг хүндэтгэх талаарх багш, сурган хүмүүжүүлэгч, эцэг, эхийн ур чадварыг дээшлүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах;
- б. Хүүхдийн асуудлаар мэргэшсэн хуульчид, социологичид, бусад мэргэжлийн хүмүүсийг бэлтгэж, сургах;
- в. Хүүхдүүдийн үзэл бодлыг үнэлж дүгнэх төв байгууллагыг байгуулах;
- г. Хэвлэл мэдээллээр дамжуулан хүүхдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг дээшлүүлэх;
- д. Хүүхдийн эрхтэй холбоотой хууль тогтоомжид хүүхдийн энэ эрхийг хуульчлан баталгаажуулах;
- е. Хүүхдийн тусгай шүүхийг байгуулж, хуульчдыг сургах.

#### **IV хэсэг. Иргэний эрх, эрх чөлөө**

##### **A. Нэр авах ба иргэний харьяалалтай байх**

###### **7 дугаар зүйл**

84. Хүүхдийн төрсний дараа нэн даруй бүртгүүлэх, нэр авах болон иргэний харьяалалтай болох эрхүүд Гэр бүлийн тухай хууль (1973 он), Гэр бүлийг бүртгэх заавар, Иргэний бүртгэлийн тухай хууль болон Паспорт болон бүртгэлийн дүрэм (1984 он)-ийн холбогдох заалтуудаар баталгаажсан. Эдгээр хууль, журамд зааснаар хүүхдийг эцэг, эх эсвэл тэдгээрийн бичгэн хүсэлтээр орон нутгийн бүртгэлийн газар бүртгүүлнэ. Хэрэв эцэг, эх хүнд өвчтэй, нас барсан эсвэл хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас биечлэн бүртгүүлэх боломжгүй бол эмнэлгийн удирдлага эсвэл асрамжийн газар эсвэл хүүхдийн төрөл төрөгсөд хүүхдийг бүртгүүлж болно. Хүүхдийг төрснөөс хойш 30 хоногийн дотор бүртгүүлэх ёстой. Эцэг, эхүүд хүүхдээ тогтоосон хугацаанд бүртгүүлээгүй бол торгууль төлнө. Хүүхдийг бүртгүүлэхэд дараах материалыг бүрдүүлэх ёстой ба нэрийг эцэг, эх өгнө. Үүнд:

- а. Хүүхэд төрсөн тухай эмнэлгийн бичиг
- б. Эцэг, эхийн паспорт
- в. Эцэг, эхийн гэрлэлтийн гэрчилгээ.

85. Хүүхдийг бүртгэсэн даруйд төрсний гэрчилгээ олгоно. Хүүхэд бүртгүүлж, төрсний гэрчилгээ авмагц Монгол Улсын иргэн болно. Монгол Улсын Иргэний харьяаллын тухай хуулийн дагуу хүүхэд төрсөн газраас үл хамааран хүүхдийн эцэг, эх хоёулаа эсвэл аль нэг нь Монгол Улсын иргэн бол Монгол Улсын иргэний харьяалалтай болно гэж заасан. Хэрэв, эцэг, эх харьяаллаа сольсон тохиолдолд 15 нас хүрээгүй хүүхэд автоматаар Монгол Улсын иргэн болно. Хэрэв хүүхэд 15 нас хүрсэн бол иргэний харьяаллын асуудлыг хүүхдийн саналыг харгалзан шийдвэрлэнэ.

86. Хаягдсан болон олдсон хүүхдийг асран хамгаалагч, асрамжийн газар эсвэл цагдаагийн байгууллага 3 хоногийн дотор орон нутгийн бүртгэлийн газар бүртгүүлнэ.

Эцэг, эх нь тогтоогдоогүй бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрт олдсон хүүхэд Монгол Улсын иргэнд тооцогдоно.

87. Шинээр төрсөн хүүхдийг бүртгэх ажлыг орон нутгийн захиргааны бүх хэсгүүд хариуцан зохион байгуулдаг. Гэвч энэ журмыг зөрчсөн тохиолдлыг бүртгэх механизм байхгүй. 1990–ээд он хүртэл бараг бүх эхчүүд хүүхдээ эмнэлэгт төрүүлдэг байсан. Энэ тохиолдолд хүүхдийг эмнэлгийн гэрчилгээнд үндэслэн бүртгэхэд амар буюу 100 хувь хамруулж байсан. Сүүлийн хэдэн жил хөдөө орон нутаг дахь эрүүл мэндийн үйлчилгээ буурсан болон ядуурлаас болж эхчүүд хүүхдээ гэртээ төрүүлэх болсноор бүртгэгдээгүй хүүхдийн тоо ихэссэн. Үүнтэй холбоотойгоор Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон Гэр бүлийн тухай хуулийн төсөлд хүүхдээ цагт нь бүртгүүлэх талаарх эцэг, эхийн үүрэг хариуцлагын талаар тусгасан.

## **Б. Хувийн онцлог байдлаа хадгалах**

### **8 дугаар зүйл**

88. Хүүхэд өөрийн хувийн онцлог байдлаа, үүнд харьяалал, нэр, бүртгэл, төрөлх хэлээрээ боловсрол эзэмших, гэр бүлийн харилцаагаа хадгалах хууль зүйн баталгааг Монгол Улс бүрдүүлж, тэдгээрийн хэрэгжилтийг хангах таатай орчин бүрдсэн.

89. Гэр бүлийн тухай хуульд зааснаар хүүхдийн нэрийг эцэг, эх нь өгөх ба хүүхэд бүртгүүлснээр Монгол Улсын иргэн болно. Иргэний харьяаллын тухай хуульд зааснаар 15 нас хүрээгүй хүүхэд эцэг, эхийн харьяаллыг авах ба 15 нас хүрсэн хүүхэд өөрийн (эцэг, эх харьяаллаа өөрчилсөн тохиолдолд) харьяаллаа сонгох эрхтэй гэж заасан.

90. Боловсролын тухай хуульд үндэстний цөөнхийн хүүхэд төрөлх хэлээрээ боловсрол эзэмших эрхтэйг зааж, Монгол Улсын баруун хэсэгт орших казах хүүхдүүд энэ эрхээ эдэлж байна.

91. Монголын Улсын Үндсэн хуульд иргэд хүүхдийнхээ хамт оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй гэж заасан.

## **В. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх**

### **13 дугаар зүйл**

92. Монгол Улсын Үндсэн хууль (1992 он) иргэдэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг олгосон. Монгол Улсын Засгийн газар хүүхдүүдэд эдгээр эрхээ эдлэх боломж бий болгох үүднээс хэвлэл мэдээлэл, радио, телевизийн тогтмол хөтөлбөрийг явуулах, энэ зорилгоор тусгай боловсон хүчнийг бэлтгэсэн.

93. Хүүхдүүд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангах боломж олгох “Өсвөр үе” тусгай сонин байдаг. Сонин 50 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байна. Монголын радио болон телевизийн хүүхдэд зориулсан тусгай нэвтрүүлэг, хөтөлбөр байдаг. Эдгээр хөтөлбөрүүдэд радиогоор “Өглөөний мэнд”, “Улаан шугам”, телевизээр “Босго”, “Хүлээ, энд хүүхдүүд байна”, “Монголын үр хүүхдүүд хөгжтүгэй” зэрэг нэвтрүүлгүүдийг нэвтрүүлдэг. Эдгээр хөтөлбөрүүд хүүхдэд үзэл бодол, саналаа илэрхийлэх боломж

олгохын зэрэгцээ төр, засгийн зүгээс хүүхдийн чиглэлээр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааг сурталчлан таниулах зорилготой. Хүүхдэд зориулсан хөтөлбөрүүд ихэнх тохиолдолд 2 хэсэгт хуваагддаг. Хөтөлбөрүүдийн 40 орчим хувь нь хүүхдэд тохиолдож буй бэрхшээлийн талаар байдаг бол, 41 орчим хувь нь хүүхдийн уран зохиол, бусад мэдээлэлд зориулагдсан байдаг.

94. Хүүхдэд зориулсан номын хэвлэлийг Засгийн газар хариуцдаг ба хүүхдэд уран бүтээлээ зориулдаг зохиолчид энэ чиглэлд онцгой үүрэг гүйцэтгэдэг. Эдгээр үйл ажиллагааны үр дүнд бие даасан хүүхдийн хэвлэлийн газар, кино студи болон номын сан бий болсон. Түүнчлэн хүүхдэд зориулж уран бүтээл туурвидаг зохиолчид цөөнгүй байдаг. Монгол дахь хүүхдийн байгууллагууд эдгээр байгууллага болон хүмүүст боломжийн хэрээр тусламж дэмжлэг үзүүлдэг. Хүүхдэд зориулсан номыг тогтмол хэвлэх болон гадаадын уран зохиолыг орчуулж хэвлэх, тэдгээрийг сургалтын хөтөлбөрт оруулах талаар тодорхой үр дүн гарсан. Жил бүр “Хүүхдийн номын баяр” арга хэмжээг зохион байгуулж, энэ үеэр хэн хамгийн их ном уншсан бэ? эсвэл номын баатартай хэн хамгийн их адилхан бэ? зэрэг уралдааныг зохион байгуулдаг.

95. Монгол Улсад хүүхэд бүр хүссэн мэдээллээ хайх эрхтэй. Сүүлийн жилүүдэд хүүхдэд зориулсан мэдээллийн хэмжээ, агуулга, эх сурвалж ихэссэн. Энэ нөхцөл байдлаас хамаарч тодорхой урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, ялангуяа садар самуун болон аймшгийн, хэрцгий кино, дүрс бичлэг зэрэг аюултай мэдээллээс хамгаалах хэрэгцээ шаардлага бий болоод байна. Кино бүтээх болон дүрс бичлэгийн клуб зэрэг бизнест хамаарах тусгай зааврыг 1993 онд баталсан.

96. Сүүлийн жилүүдэд сургууль завсардсан хүүхдүүдийн тоо ихсэж байна. Үүнээс хамаарч олон хүүхдүүд хэрэгтэй мэдээллээ авах боломжоор хязгаарлагдмал байна. Ялангуяа эдгээрт хөдөө орон нутаг дахь малчин өрхийн хүүхдүүд болон хот суурин дахь ядуу өрхийн хүүхдүүд хамаарч байна. Өнөөдрийн байдлаар сургууль завсардалтын тоо 106,000 хүрч, үүний үр дүнд эдгээр хүүхдүүд мэдээлэл хүлээн авах нь хязгаарлагдмал бөгөөд өөрсдийгөө илэрхийлэх боломж хомс байна.

97. Сөрөг хүчин зүйлүүд болон бэрхшээлүүд.

- а. Сүүлийн жилүүдэд хэвлэлийн цаасны хомсдол болон чадавх муу, түүнчлэн үнийн өсөлтөөс хамаарч хүүхдийн ном, хэвлэлийн тоо буурч байна.
- б. Санхүүгийн бэрхшээлтэй холбоотойгоор радио, телевизийн хөтөлбөрүүд хүүхдийн наснаас хамаарч ангилагдах боломжгүй болсон.
- в. Аймаг, хот, сумдуудын хүүхдийн олон номын сан хаагдаж, номын сангаар үйлчлүүлэх хүүхдийн тоо буурсан.

98. Авах арга хэмжээнүүд:

- а. Мэдээлэл хүлээн авах боломжгүй байгаа хүүхдүүдэд хүрч ажиллах арга хэмжээ авах;
- б. Хүүхдэд зориулсан ном, хэвлэл, сонин тоо, чанарыг дээшлүүлэх үүднээс Засгийн газрын зүгээс ном, хэвлэл нийтлэх ажилд дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авах;
- в. Хөдөө орон нутаг дахь хүүхдэд үзэл бодол, саналаа илэрхийлэх боломж олгох үүднээс шуудангийн үнийн хөнгөлөлт үзүүлэх;

- г. Хүүхдийн нэвтэрхий толь, танин мэдэхүйн холбогдолтой номыг хэвлэх, мэдээллийг түгээх тогтолцоог сайжруулах арга хэмжээ авах;

### **Г. Эвлэлдэн нэгдэх, тайван замаар цуглах эрх**

#### **15 дугаар зүйл**

99. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 10–т Монгол Улсын иргэн бүр нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй бөгөөд иргэнийг гишүүнийх нь хувьд ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглосон. Түүнчлэн тайван замаар жагсаал, цуглаан хийхийг Үндсэн хуулиар баталгаажуулсан. Үүнийг Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулиар (1994) зохицуулсан.

100. Өнөөдрийн байдлаар Монгол Улсад хүүхдийн сайн дурын зургаан байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Үүнд 8,000 гишүүнтэй Сүхбаатарын нэрэмжит Монголын хүүхдийн Байгууллага, Монголын өсвөр үеийнхний холбоо (албан ёсны гишүүнчлэлгүй хөдөлгөөн), 5,000 гишүүнтэй Монголын скаутын холбоо, 900 гишүүнтэй Залуу техникчдийн холбоо, Эх дэлхий холбоо (гишүүнчлэлгүй), 500 гишүүнтэй Гадаад хэл сонирхогчдын холбоо зэрэг орно. Монголын хүүхдийн холбоо бусад байгууллагад дэмжлэг тусалцаа үзүүлэх, хамтарч ажиллах зорилгоор 1991 онд байгуулагдсан. Хөдөө орон нутагт тухайн орон нутгийн хүүхдийн дуу хоолой, үзэл бодлыг илэрхийлэх боломжийг хангах хэд хэдэн хүүхдийн холбоо, нийгэмлэг үйл ажиллагаа явуулж байна.

101. Хүүхдүүдийн эвлэлдэн нэгдэх эрхэд ямар нэгэн хязгаарлалт байхгүй бөгөөд Засгийн газрын бодлого түүний байгууллагуудаар дамжин энэ эрхийг аль болох эдлүүлэх боломжийг хангах байдлаар илэрч байна. Энэ эрхийн талаарх ерөнхий хандлага эерэг байна. Гэвч зарим нэг бэрхшээлүүд учирч байна. Үүнд:

- а. Эдгээр хүүхдийн байгууллагуудын санхүүжилтийн талаар ерөнхий зохицуулалт байхгүй байна.
- б. Засгийн газрын зүгээс эдгээр байгууллагад тодорхой дэмжлэг үзүүлэх зохистой тогтолцоо байхгүй байна.

102. Энэхүү бэрхшээлийг харгалзан дараах арга хэмжээнүүдийг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- а. Төрийн бус байгууллага болон Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлийн хуулийн төслүүдэд хүүхдүүдийн эвлэлдэн нэгдэх эрхийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлж тусгах;
- б. Хүүхдийн байгууллагуудад Засгийн газрын дэмжлэг дор үйл ажиллагаа явуулах боломж олгох тогтолцоо бий болгох;
- в. Хүүхдүүд эвлэлдэн нэгдэх эрх чөлөөгөө эдлэхэд нь дэмжлэг үзүүлэх мэргэжилтнүүд, багш нарт зориулсан сургалт зохион байгуулах;

#### **Д. Хувийн нууц хадгалах**

##### **16 дугаар зүйл**

103. Монгол Улсын Үндсэн хуульд “иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэж тунхагласан. Монгол Улсын Эрүүгийн хуулийн дагуу энэхүү эрхийг зөрчих нь гэмт хэрэгт тооцогддог. Түүнчлэн Монгол Улсын Иргэний хуульд хүүхдийн эцэг, эх нас барсан эсвэл асрамжийн газар шилжиж байгаа тохиолдолд эцэг, эхийн орон байрыг хүүхэд өвлөж авах эрхтэй гэж заасан. Тухайн байрыг түр хугацаагаар эзэмшиж оршин сууж буй этгээд хүүхдийг шаардсан даруйд орон байрыг чөлөөлж өгөх үүрэгтэй. Хэрэв шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд шүүхийн шийдвэрээр асуудлыг шийдвэрлэнэ. Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд зааснаар шүүхийн шийдвэргүйгээр аливаа нэгжлэг хийх, баривчлах, урьдчилан хорих, хорих, яллах болон эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглосон.

104. Эдгээр эрхийг хуулиар баталгаажуулсан боловч хүүхдүүдийн эрхээ мэдэж, эдлэх талаарх мэдлэг хангалтгүй байдаг. Бидний зорилго бол хүүхдүүдэд эдгээр эрхээ мэдэх, хэрэгжүүлэхэд нь туслах, мөн эдгээр эрхүүдийг хууль тогтоомжид ойлгомжтойгоор тусгах явдал юм.

#### **Е. Эрүүдэн шүүх болон хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх**

##### **37 дугаар зүйл**

105. 18 нас хүрээгүй хүүхдийн сэтгэхүйн болон бие махбодийн онцлогийг харгалзан Эрүүгийн хууль болон Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулиар тусгай хамгаалалт бий болгосон. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13, 14–р хэсэг болон Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 12 дугаар зүйлд “хэнийг ч эрүүдэн шүүх, хүнлэг бус, хэрцгийгээр нэр төрийг нь доромжлон харьцаж, шийтгэж болохгүй бөгөөд эрхээ шүүхээр хамгаалуулах эрхтэй” гэж заасан. Эрүүгийн хуулийн 201 дүгээр зүйл гэм буруугүй хүнийг эрүүгийн хариуцлагад татахаас хамгаалсан. Мөн хуулийн 203 дугаар зүйлд нь хууль бусаар эрүүгийн хариуцлага ногдуулах болон хууль бус шийдвэр гаргахыг хориглосон. Эрүүгийн хуулийн 206 дугаар зүйлд хэнийг ч мэдүүлэг өгүүлэхээр албадаж болохгүй гэж заасан.

106. Эдгээр хуулиудын заалтууд нь хүүхдийн эрхийг хамгаалахад чухал үүрэгтэй бөгөөд хүүхдийн талаарх шүүхийн бодлого хүүхдийн эрх ашгийг дээд зэргээр хангахад чиглэгддэг. Цагдаагийн байгууллагад хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхдийг гэмт халдлагаас хамгаалах тусгай нэгж ажилладаг. Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн эсвэл дахин гэмт хэрэг үйлдсэн онцгой тохиолдолд хүүхдэд хорих ял оногдуулж болохоор заасан бөгөөд Эрүүгийн хуулийн 22 дугаар зүйлд 18 насанд хүрээгүй хүүхдэд 10 жилээс илүү хугацаагаар хорих ял оногдуулахыг хориглосон.

107. Энэ талаарх хүүхдийн эрхийг хамгаалах хуулиудын заалт болон төрийн бодлого тийм ч муу биш байна. Гэсэн хэдий ч хойд эцэг, эхтэйгээ амьдарч буй хүүхдүүдийн бодит нөхцөл байдал болон хохирогч хүүхдүүдийн тооны талаар бодитой судалгаа хийгдээгүй

байна. Ихэнх тохиолдолд хүүхдүүд эрхээ мэддэггүй бөгөөд зөрчигдсөн тохиолдолд хаана, хэнд хандахаа мэддэггүй. Тиймээс энэ талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх, тэдгээрийн үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай байна.

108. Авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд:

- а. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийг тусгах;
- б. Хүүхдийн гэр бүл дэх нөхцөл байдлыг тодорхойлох тусгай судалгаа явуулах, хохирогч хүүхдийн эрхийг тодорхойлох болон тэдгээрийн нөхцөл байдлыг дээшлүүлэх тодорхой арга хэмжээ авах;
- в. Эдгээр асуудлыг шийдвэрлэх тусгай боловсон хүчнийг бэлтгэх;

## **V хэсэг. Гэр бүлийн орчин ба түүнийг орлох халамж үйлчилгээ**

### **А. Эцэг, эхийн үүрэг хариуцлага**

#### **18 дугаар зүйл**

109. Монгол Улсын Үндсэн хуульд “үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг” гэж тунхагласан. Үндсэн хуулийн энэхүү заалт нь Боловсролын, Иргэний, Гэр бүлийн болон Хөдөлмөрийн тухай хуулиудад тусгалаа олсон. Эрүүл саруул, боловсролтой хүүхэд өсгөж хүмүүжүүлэх талаарх асуудлууд хуульд тодорхой тусгагдсан. Эдгээр заалтууд нь эцэг, эхийн хүлээх хариуцлагын хууль зүйн үндэс нь боловч эцэг, эхчүүдэд хүүхэддээ зохих ёсоор анхаарал халамж тавьж, өсгөхөд шаардлагатай эдийн засгийн болон нийгмийн таатай орчин хангалттай бүрдээгүй байна. Сүүлийн 70 гаруй жилд эцэг, эхчүүд үр хүүхдээ өсгөж хүмүүжүүлэх уламжлалт арга барилаас хөндийрч, бүхнийг цэцэрлэг, сургуульд даатгах болсон. Энэ нь нэг талаар эцэг, эхчүүдийн ажиллах, хөдөлмөрлөх нөхцөл байдал болон үр хүүхдүүдтэй өнгөрүүлэх чөлөөт цаг байхгүй байсантай холбоотой. Одоогийн байдлаар өрхийн эдийн засгийн чадавх доогуур байна. Ойролцоогоор нийт өрхийн 40 орчим хувь нь үр хүүхдийнхээ хэрэгцээ шаардлагыг хангаж чадахгүй байна. Нөгөө талаас ерөнхий боловсролын сургуулиуд хүүхэдтэй холбоотой бүхий л асуудлыг хариуцан зохион байгуулж, улмаар хүүхдүүд эцэг, эхээсээ илүү сургуультайгаа ойр дотно харьцаатай болж өссөн нь нөлөөлсөн.

110. Гэвч сүүлийн жилүүдэд, сургуулиуд сурагчдад зориулж тийм ч олон төрлийн үйл ажиллагаа явуулахаа больсон бөгөөд эцэг, эхчүүд хүүхэддээ анхаарал тавихгүй байна. Энэ нөхцөл байдлаас болж хүүхдүүд тодорхой анхаарал халамжгүй орхигдож байна. Үүний уршгаар, орон гэргүй тэнэмэл хүүхдийн тоо өсөж, ялангуяа, хөдөө орон нутагт сургууль завсардалт ихсэхэд нөлөөлж байна.

111. Одоогийн нөхцөл байдалд хэд хэдэн хүчин зүйлүүд нөлөөлж байна. Жишээ нь эдийн засгийн бэрхшээлээс хамааран эцэг, эх хоёулаа ажиллах шаардлагатай болж улмаар хүүхэд хараа хяналтгүй үлдэж байна. Нөгөө талаар эдийн засгийн бэрхшээлээс хамаарч цэцэрлэг, сургуулиуд хүүхдүүдэд чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэхэд чиглэсэн төрөл бүрийн үйл ажиллагааг зохион байгуулах боломжгүй байна. Энэ байдал

ядуу өрхийн хүүхдүүдэд бүр хүндрэлтэй байна. Эдгээр өрхүүдийн ихэнх нь үр хүүхэддээ хувцас авах болон хичээлийн хэрэгсэл худалдан авах чадваргүй байна. Үүний үр дүнд эдгээр өрхүүдийн хүүхдүүд сургууль завсардах хандлага өсөж байна. Гэсэн хэдий ч зарим ядуу өрхүүд хүүхдээ өсгөж хүмүүжүүлэх үүргээ биелүүлж байна. Одоогийн байдлаар Монгол Улсын Засгийн газар эцэг, эхийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх бодлого баримталж байна. Гэвч үр хүүхдээ өсгөж хүмүүжүүлэх талаар эцэг, эхчүүдэд системтэй сургалт, зөвлөгөө өгөх ажил хангалтгүй байна.

112. 1991 оноос хойш нийгмийн даатгалын хүрээнд эцэг, эхчүүдэд хүүхдээ өсгөж хүмүүжүүлэх санхүүгийн дэмжлэг үзүүлж байна. 1991 оны 10 дугаар сарын 4–ний өдрийн Засгийн газрын 28 дугаар тогтоолоор хүүхдийн хувцасны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, болон Сангийн, Худалдаа, Аж үйлдвэрийн болон Боловсролын сайд нарын ядуу өрхийн хүүхдэд хувцас олгох тусламжийн сан байгуулах тухай хамтарсан шийдвэр зэрэг нь эергээр нөлөөлсөн. 1992 оны 9 дүгээр сарын 28–ны өдрийн Засгийн газрын 34 дүгээр тогтоолоор ядуу, орлого багатай өрхүүдэд дэмжлэг үзүүлэх Тусламжийн сан байгуулагдсан бөгөөд Хөдөлмөрийн сайд болон Сангийн сайд нарын хамтарсан 267/213 тоот шийдвэрээр тус сангийн дүрэм, журмыг боловсруулсан. Энэ сан нь хувцас, хичээлийн хэрэгсэл олгох болон мэргэжлийн сургалт явуулах хэлбэрээр дэмжлэг үзүүлдэг. 1993 оны 2 дугаар сарын 23–ны өдрийн төрөөс нярай хүүхдэд сүү олгох талаарх Засгийн газрын 34 дүгээр тогтоолыг үндэслэн Сангийн яам, Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам болон Эрүүл мэндийн яам бага орлоготой өрхийн нэг хүртэлх настай хүүхдэд олгох сүүний үнийг 50 хувиар бууруулах шийдвэр гаргасан. Сангийн Сайд болон Боловсролын Сайдын 1993 оны 2 дугаар сарын 1–ний өдрийн 23/31 тоот тушаалаар эцэг, эхчүүд цэцэрлэгийн хоолны зардалд хөнгөлөлт эдлэхээр болсон.

113. Эдгээр шийдвэрийг хөгжүүлэхэд гарч буй бэрхшээлүүд:

- а. Шилжилтийн үед олон өрх үр хүүхдээ өсгөж хүмүүжүүлэхэд эдийн засгийн бэрхшээлтэй учирч байна.
- б. Олон хүүхэдтэй айл өрхөд энэхүү шинэ нөхцөлд оршин тогтнох болон хэрхэн амьдралаа дээшлүүлэх талаар сургах, тэдэнд туслах зохистой тогтолцоо байхгүй байна.
- в. Эцэг, эхчүүд үр хүүхдээ өсгөж хүмүүжүүлэх үүрэг хариуцлагаа хэрхэн биелүүлж буй талаар судалгаа хийгдээгүй бөгөөд үр хүүхдээ өсгөх талаар эцэг, эхчүүдэд туслах бодлого байхгүй байна.
- г. Нийгмийн ихэнх гишүүд “надад туслаач” гэсэн муу зуршилтай болсон бөгөөд ялангуяа ядуу хүмүүс бие даан аж амьдралаа дээшлүүлэх арга замыг эрэлхийлэхэд хойрго хандаж байна.

114. Одоогийн нөхцөл байдлыг харгалзан бид дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

- а. Эцэг, эхийн үр хүүхдээ өсгөх чадварыг дээшлүүлэх болон хүүхдэд гэр бүлийн боловсрол олгох талаар арга хэмжээ авах;
- б. Гэр бүлд чиглэсэн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх талаарх Засгийн газар болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зохистой систем бий болгох;

- в. Ажил олгогч нарт ажилтнууддаа үр хүүхдээ өсгөж хүмүүжүүлэх нөхцөл, боломжийг олгох талаар шаардлага тавьж, хэрэгжилтийг хянах;
- г. Гэр бүлд туслах зорилгоор гэр бүлийн амьдралын талаар шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа явуулж, сургалт зохион байгуулах;
- д. Хүүхдүүдтэй ажилладаг байгууллагуудын үйл ажиллагааг өргөжүүлэх;
- е. Үр хүүхдээ өсгөхтэй холбоотой асуудлаар эцэг, эхчүүдэд зөвлөгөө өгөх, тэдэнд дэмжлэг үзүүлэх;

## Б. Эцэг, эхээс тусгаарлах

### 9 дүгээр зүйл

115. Монгол Улсын Үндсэн хуулийн 17 дугаар зүйлд үр хүүхдээ өсгөж хүмүүжүүлэх нь Монгол Улсын иргэн бүрийн журамт үүрэг гэж заасан. Үндсэн хуулийн энэ заалт нь бусад холбогдох хуулийн хууль зүйн үндэс нь юм. Гэр бүлийн тухай, Иргэний хууль болон Эрүүгийн хуульд эцэг, эхийн үр хүүхдээ өсгөж хүмүүжүүлэх үүрэг хариуцлагыг тодорхойлж, биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэхээр заасан. Эдгээр нь хүүхдүүд эцэг, эхтэйгээ хамт гэр бүлдээ өсөж бойжих хууль зүйн гол үндэс юм.

116. Эцэг, эхийн үр хүүхдээ өсгөж хүмүүжүүлэх үүрэг хариуцлагыг хуулиар тодорхойлохын зэрэгцээ хүүхдийн эрх ашгийн үүднээс тэдгээрийг эцэг, эхээс нь тусгаарлах тодорхой тохиолдлууд байдаг. Гэр бүлийн тухай хуулийн 44 дүгээр зүйлд эцэг, эх хүүхдийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсвэл тухайн гэр бүлд хүчирхийлэл тогтмол явагддаг бол шүүхийн шийдвэрээр эцэг, эх байх эрхийг нь хасаж болно гэж заасан.

117. Хүүхдийн нөхцөл байдлыг сайжруулахын тулд:

- а. Гэр бүлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд эцэг, эхийн хүүхдээ өсгөж хүмүүжүүлэх үүргийн талаар заасан. Түүнчлэн хуульд эцэг, эх хүүхдийнхээ өмнө адил тэгш хариуцлага хүлээхээр зааж, гэр бүл салсан тохиолдолд хүүхдээ өөрийн асрамждаа аваагүй нь нөгөөдөө тэтгэмж өгөхөөр заасан.
- б. Гэр бүлийн тухай хуулийн 60 дугаар зүйлд хүүхдийн эрх ашгийг харгалзан сонирхол бүхий этгээд эсвэл хууль ёсны асран хамгаалагч, прокурор, улс болон олон нийтийн байгууллагын хүсэлтийг үндэслэн шүүх хүүхдийн тэжээн тэтгүүлэх тэтгэврийг тогтооно гэж заасан. Тэтгэмжийг тэтгэмж авч буй хүүхдийн тооноос хамаарч сарын дундаж цалингийн тодорхой хувиар тогтооно. Хэрэв эцэг, эх хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тэтгэмж төлөөгүй эсвэл хугацаанд нь төлөөгүй тохиолдолд шүүх түүнийг төлөхийг шаардах буюу түүний орлогыг энэ зорилгоор хураан авна.
- с. Хуулийн 47 дугаар зүйлд хэрэв хүүхэд эцэг, эхийн аль нэг, эсвэл хоёулантай нь байвал түүний ашиг сонирхолд харшилна гэж үзвэл хүүхдийг асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэх шийдвэрийг шүүх гаргана гэж заасан. Гэр бүлийн орчин сайжирсан тохиолдолд шүүхийн шийдвэрээр хүүхэд өөрийн эцэг, эхдээ буцаж очиж болно.

118. Өөрөөр хэлбэл зөвхөн шүүх хүүхдийг тусгаарлахтай холбоотой асуудлыг шийдвэрлэнэ. Хэрэв хэн нэгэн этгээд хууль ёсны шийдвэргүйгээр хүүхдийг өөртөө авсан



тохиолдолд эцэг, эх шүүхэд хандах эрхтэй. Эцэг, эх байх эрх нь хязгаарлагдсан эсвэл хүүхдийг тусгаарласан тохиолдолд ч эцэг, эх хүүхдийнхээ өмнө үүрэг хариуцлага хүлээнэ. Энэ заалтын зорилго нь хүүхэд, эцэг, эхийн хоорондын харилцааг хадгалах явдал юм. Эцэг, эхийн зан байдал засарсан тохиолдолд хүүхдийг гэр бүлд нь буцаана.

119. Холбогдох хуулийн заалт буй ч тэдгээрийн хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна. Хуулийг зөрчих явдал ихсэж байна. Хүүхэд гэр бүлээсээ тусгаарлагдсан тохиолдолд гарах үр дагавар, нөлөөг судлах байгууллага байхгүй байна. Түүнчлэн гэр бүлээсээ тусгаарлагдсан хүүхэдтэй ажиллах байгууллага, мэргэжилтэн байхгүй байна. Иймээс дараах арга хэмжээг авах шаардлагатай байна.

- а. Хүүхдийг тусгаарлахтай холбоотой асуудлыг шинээр батлагдах, Гэр бүлийн тухай хууль болон Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулиар хуульчлах;
- б. Эдгээр асуудлыг шийдвэрлэх тусгай шүүх бий болгож, боловсон хүчнийг бэлтгэх;
- в. Хүүхдийг гэр бүлээс нь тусгаарлахгүй байх боломжит бүх урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;
- г. Гэр бүлээсээ тусгаарлагдсан хүүхдүүдийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгаа хийж, тэдний амьжиргааны түвшинг дээшлүүлэх;

120. Хууль зүйн яам 1991 онд хүүхдийн тэтгэмжийн талаар журам гаргаж, улмаар 1991–1994 онуудад 139 хүн 163.3 мянган төгрөгийн тэтгэмж авсан байна.

121. Ихэнх эцэг, эх тусгаарлагдсан хүүхэддээ сайн дураар тэтгэмж төлдөг бөгөөд төлөөгүй тохиолдолд шүүх торгууль ногдуулна. 1993 он гэхэд 8,800 иргэн 16,200 хүүхэдэд (21 сая төгрөг) шүүхийн шийдвэрээр тэтгэмж төлсөн байна. Ажилгүйдэл болон тогтмол орлогогүйн улмаас 3,800 иргэн тэтгэмж төлөөгүй байна. Нөгөө талаар тэтгэмжийн доод хэмжээ хүүхдийн наад захын хэрэгцээг хангаж чадахгүй байна. Үүнтэй холбоотойгоор шинээр батлагдах Гэр бүлийн тухай хуульд хувийг өөрчилж тогтооно.

122. Өнөөдрийн байдлаар Монгол Улсад 451,600 гэр бүл бүртгэгдсэн бөгөөд 54 хувь нь хот суурин газар, 46 хувь нь хөдөө орон нутагт амьдарч байна. Эдгээр гэр бүлийн 76 хувь нь 16–аас доош насны хүүхэдтэй. Тэдгээрийн 70.2 хувь 1–3 хүүхэдтэй, 27.1 хувь нь 4–6 хүүхэдтэй бөгөөд 2.7 хувь нь 7 ба түүнээс дээш хүүхэдтэй. Мөн 70,000 гаруй хүүхэдтэй 20,000 гаруй өрх толгойлсон эмэгтэйчүүд байна.

123. Монгол Улсын шалгуурын дагуу өрхийн нэг хүнд ногдох сарын орлого нь амьжиргааны баталгаажих доод түвшингийн 40 хувиас доогуур байвал хоол хүнсээ худалдаж авах чадваргүйд тооцогдож нэн ядуу өрхөд хамаардаг. Энэхүү шалгуурын дагуу ядуу өрхийн 60 хувь буюу 51,600 нь нэн ядуу өрхөд тооцогддог. 1992 оны Засгийн газрын 34 дүгээр тогтоолоор тусгай сан байгуулагдсан. Энэхүү сангийн зорилго нь эдгээр ядуу өрхөд хөнгөлөлттэй зээл олгох зэргээр бүх төрлийн дэмжлэг үзүүлэх явдал юм.

124. 1993 онд мөнгөн тусламжийг 11,600 ядуу хүнд (12.8 сая төгрөг), 681,300 төгрөгийн хувцсыг 2,300 хүнд болон 3,2 сая төгрөгийн хоол хүнсний дэмжлэгийг 7,800 хүнд үзүүлсэн байна. Улаанбаатар хотын зургаан дүүрэг, 5 аймаг болон Эрдэнэт хотуудад тусламжийн төвүүд байгуулагдсан. Эдгээр төвүүдэд 320–350 хүн үнэгүй хоол идэх боломжтой бөгөөд мөн эдгээр төвүүд ядуу иргэдийн гэр бүлд дэмжлэг үзүүлэх бусад төрлийн үйл ажиллагаа явуулдаг. 1993 онд ажил хийх чадвартай 150 ядуу иргэнд тус бүр

нэг сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Эдгээр гэр бүлийн 1 хүртэлх насны хүүхэд сүүг хагас үнээр нь авах эрхтэй бөгөөд 1993 онд Засгийн газар энэ зорилгоор 9.1 сая төгрөгийг зарцуулсан.

125. Учирч буй бэрхшээлүүд:

- а. Ядуу өрх, хүмүүсийн тоо ихсэж байна.
- б. Ажлын байр хомс учраас сургууль төгсөгчид ажилгүйчүүдийн эгнээнд орж улмаар ядуучуудын тоо нэмэгдэж байна.
- в. Олон хүмүүс уламжлалт сэтгэлгээгээр буюу бусдын гарыг харж амьдарч байна.
- г. Хөдөлмөрийн чадвартай ядуу хүмүүст дэмжлэг үзүүлэхийг улс орны эдийн засгийн хүчин чадал хангаж чадахгүй байна.

126. Энэхүү хүнд бэрхшээлийг даван туулах арга зам бол хүүхдийг бага наснаас нь хөдөлмөрлөх болон амьдралын арга ухаанд сурган өсгөж, хүмүүжүүлэх явдал юм. Энэ зорилгоор Засгийн газар ажлын байр нэмэгдүүлж ажилгүйдлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. (1993 оны 134 дүгээр тогтоол) Энэ тогтоолд 8 болон 10 дугаар анги төгсөөд их, дээд сургуульд суралцах боломжгүй эсвэл хөдөлмөр эрхлэх боломжгүй хүүхдэд өөрсдийн бизнес эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх талаар заасан. Энэ зорилгоор Засгийн газар шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл түрээслүүлэх юм.

127. Гэр бүлийн үр хүүхдээ өсгөж хүмүүжүүлэх боломжийг олгох шинэ нийгмийн халамжийн тогтолцоо болон хууль тогтоомжийг боловсруулах ажил хийгдэж байна.

## **В. Гэр бүлийн орчноос хагацсан хүүхдүүд**

### **20 дугаар зүйл**

128. Гэр бүлийн орчин болон эцэг, эхийн халамжаас гадуур байгаа хүүхдийн асуудлыг Гэр бүлийн тухай хуулиар зохицуулдаг. Гэр бүлийн тухай хуулийн 76 дугаар зүйлд Засгийн газар эдгээр хязгаарлагдсан хүүхэд болон тэдгээрийн амины болон эд хөрөнгийн эрх ашгийг хамгаалах журмыг тогтооно гэж заасан.

129. Гэр бүлийн орчноос бүрэн хагацсан, ялангуяа өнчин хүүхдэд онцгой анхаарал хандуулдаг. Юуны өмнө, энэ зорилгоор авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдэд судалгаа явуулж эдгээр хүүхдүүдийн хэрэгцээг тодорхойлох бүртгэл юм. 1993 онд 0–16 насны 942,800 хүүхэд байсан ба 6.2 хувь буюу 4,427 нь өнчин, тэдгээрийн 1,007 нь 0–6 насны 3,420 нь 7–16 насны хүүхэд байсан. Эдгээр хүүхдүүдэд асран хамгаалагч, харгалзан дэмжигч шаардлагатай байна. Түүнчлэн 1,268 хүүхэд тэдгээрийг асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл садангүй байна. Эдгээр хүүхдүүд маш хүнд нөхцөлд амьдарч байна. 1989 оноос өмнө буюу төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед эдгээр хүүхдүүд холбогдох хууль тогтоомжийн дагуу төрийн халамжинд байсан. Харин өнөөдрийн шинэ нөхцөлд тэдгээр хуулиуд хэрэгжих боломжгүй юм.

130. Гэр бүлийн тухай хуулийн 78 дугаар зүйлд гэр бүлийн орчноосоо түр хугацаагаар тусгаарлагдсан хүүхдийг асран хамгаалах буюу харгалзан дэмжих талаар заасан. Энэ зүйлд эцэг, эх нь хорих байгууллагад хоригдож буй эсвэл эмнэлэгт удаан

хугацаагаар хэвтэж буй эсвэл үр хүүхдээ асрах чадваргүй хүмүүсийн хүүхдүүд хамаардаг.

140. Түүнчлэн эцэг, эхийн хайр халамж дутагдсан болон ядуурлаас болж тэнэмэл хүүхдүүдийн тоо ихсэж байна. 1993 он гэхэд цагдаагийн байгууллагад бүртгэлтэй галт тэргэнд өдөр хоногийг өнгөрөөдөг хүүхдийн тоо 1,000 гаруй байсан. Түүнчлэн байнгын тэнэмэл хүүхдүүдийг дагалддаг 3,000 гаруй хүүхэд байна. Эдгээр нь нийт хүүхдүүдийн 5 хувийг эзэлдэг ба тэдгээрийн 7 хувь нь эрэгтэй, ойролцоогоор 5 хувь нь эмэгтэй байх бөгөөд тэдгээрийн дундаж нас 11–13 байна. Эдгээр хүүхдүүдийн гэр бүлдээ эргэж очих болон тэднийг хамгаалах асуудал хүүхдийн байгууллагуудын гол анхаарал татаж буй асуудал болоод байна.

131. Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотод нийт өнчин хүүхдийн зөвхөн 3 хувьд хүрч ажиллаж чадах нэг асрамжийн төв үйл ажиллагаа явуулж байна. Түүнчлэн тэнэмэл хүүхдүүдийн 0.3 хувьд хүрч ажиллах боломж бүхий “Итгэл” төв Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна.

132. Гэр бүлийн орчноос түр эсвэл бүрэн хагацсан хүүхдэд чиглэсэн бүх түвшний тусгай хөтөлбөр боловсрогдсон. Энэ хөтөлбөрийн гол агуулга нь:

- а. Эдгээр хүүхдүүдэд асран хамгаалагч, харгалзан дэмжигч томилох, үрчлүүлэх, эдгээр хүүхдүүдэд гэр бүлийн орчинд өсөж бойжих боломж бүрдүүлэх, хуулийн дагуу үрчлэлтийг зохион байгуулах, асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй хүүхдүүдийг асрамжийн газар байрлуулах
- б. Эдгээр хүүхдүүдийг амьдралын арга ухаанд сургах, мэргэжлийн сургалтад хамруулах, сурч боловсрох эрхийг хангах болон хөнгөлттэй зээл олгох зэрэг орон нутгийн хөтөлбөрийг боловсруулах
- в. Тэдгээр хүүхдүүдэд хууль зүйн зөвлөгөө өгч, эрхийг нь эдлүүлэх
- г. Эдгээр хүүхдүүдэд туслах олон нийтийн хүчин чадлыг ашиглах болон тэдний үйл ажиллагааг дэмжих бүх төрлийн туслалцаа үзүүлэх

134. Бэрхшээлүүд:

- а. Эдгээр хүүхдүүдийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх нэгдсэн хууль тогтоомж байхгүй.
- б. Бүх хүүхдэд хүрч ажиллах, дэмжлэг үзүүлэх санхүүгийн эх үүсвэр байхгүй.
- в. Эдгээр хүүхдүүдтэй ажиллах мэргэжлийн боловсон хүчин байхгүй.

Энэ бэрхшээлийг даван туулахын тулд эдгээр хүүхдүүдэд дэмжлэг үзүүлэх хууль тогтоомжийг батлах болон тэдгээртэй ажиллаж буй хүмүүсийн мэргэжлийн түвшинг дээшлүүлэх шаардлагатай байна.

## Г. Үрчлэлт

### 21 дүгээр зүйл

135. 1973 оны Гэр бүлийн тухай хуулийн 48 дугаар зүйл үрчлэлтэй холбоотой асуудлыг зохицуулдаг. Энэхүү зүйлд зааснаар хосууд анх гэрлэлтээ бүртгүүлэхдээ өмнөх гэрлэлтийн үед бий болсон хүүхдээ өөрийн хүүхдийн нэгэн адил тооцно гэдгээ хүлээн зөвшөөрдөг. Хүүхдийн өвөө, эмээ нар хүүхдийн эцэг, эх болон асрамжийн газрын зөвшөөрлөөр ач, зээ нараа үрчилж авах эрхтэй. Бусад бүх тохиолдолд хүүхдийг үрчлэх

асуудлыг хүүхдийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны байгууллагын шийдвэрээр зохицуулдаг.

136. Нэг нас хүрээгүй буюу эхийн сүүнээс гараагүй хүүхдээс бусад 16 насанд хүрээгүй хүүхдийг үрчилж болно. Хүүхдийг үрчилж авахад эцэг, эхийн өргөдөл болон орон нутгийн захиргааны байгууллагын зөвшөөрөл байх ёстой. Гурван нас хүрээгүй хүүхдийн хувьд эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт, 9 наснаас дээш насны хүүхдийн хувьд тухайн хүүхдийн санал зэргийг авсан байх ёстой. Харин эцэг, эх байх эрх нь хязгаарлагдсан, эцэг, эхийн үүргээ биелүүлээгүй, сэтгэл мэдрэлийн өвчтэй эсвэл оршин суугаа газар нь тодорхойгүй эцэг, эхийн хувьд зөвшөөрөл авах эрхгүй.

137. Гэр бүлийн тухай хуулийн 53, 54 дүгээр зүйлүүдийн дагуу үрчлэн авсан хүүхэд, үрчлэн авагчид болон тэдгээрийн төрөл садны хооронд төрсөн хүүхдийн адил төрөл садны холбоо тогтож, хуулиар тогтоосон төрөл садны эрх, үүрэг үүснэ гэж заасан.

138. Өнчин хүүхэд үрчлүүлэхээс өмнө авч байсан тэтгэмж авах эрхээ хадгална. Нэгээс доош насны хүүхдийг үрчилж авч буй эхийн хувьд амаржсаны болон хүүхэд асарсны тэтгэмж авах зэргээр хүүхэд төрүүлсэн эхийн нэгэн адил хөнгөлөлт, эрхийг эдэлнэ.

139. Хүүхдийг өөр улсын иргэнд үрчлэхийг зохицуулсан хууль тогтоомж байхгүй бөгөөд энэ асуудлыг эрхлэн зохион байгуулах байгууллага байхгүй байна. 1991 оноос хойш гадаадын иргэдээс хүүхэд үрчлэн авах тухай хэд хэдэн хүсэлт гаргасан. Монгол Улсын Үндсэн хуулийн Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээр нь дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ гэсэн заалтын дагуу Герман болон Америк Улсын иргэд Монгол Улсын хүүхдийг үрчилж аваад байна. Үрчлэлтийг орон нутгийн засаг захиргааны бүртгэлийн байгууллага бүртгэж байна. Монголын хүүхдийн эрхийн байгууллагууд хүүхэд үрчлэх тогтолцоо болон хууль Хүүхдийн эрхийн тухай конвенцийн шаардлагыг хангахгүй байна гэж үздэг. Иймээс үрчлэлтийг зохицуулах тусгай хууль батлах тохиолдол тус хуулийг хэрэгжүүлэх байгууллага шаардлагатай байна.

#### **Д. Хууль бусаар шилжүүлэх, буцаахгүй байх**

##### **11 дүгээр зүйл**

140. Эдийн засгийн бэрхшээлтэй холбоотойгоор олон өрхүүд хүүхдээ зохих ёсоор өсгөн хүмүүжүүлэх болон тэдгээрийн материаллаг хэрэгцээг хангах чадваргүй болоод байна. Улмаар тэнэмэл болон хаягдмал хүүхдийн тоо ихсэж байна. Монгол Улсын Засгийн газар энэ асуудалд анхаарлаа хандуулж, Хүүхдийг хөгжүүлэх талаар 2000 он хүртэл баримтлах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр, Ядуурлыг бууруулах хөтөлбөр зэрэг үүнтэй тэмцэх бодлого боловсруулж, хэрэгжүүлж байна. Түүнчлэн 1994 оноос эхлэн НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран тэнэмэл хүүхдүүдэд туслах төслийг хэрэгжүүлж байна. Эдгээр хөтөлбөр, төслүүдийн гол цөм нь хүүхэд гэр бүлийн хүрээнд өсөж бойжих, болон энэ чиглэлээр эцэг, эхчүүдэд дэмжлэг үзүүлэх, мөн өнчин хүүхдүүдэд гэр бүлийн орчныг орлох халамжийг үзүүлэх зорилготой юм.

141. Хууль ёсны төрсөн эцэг, эхтэй болон эцэг, эхгүй хүүхдүүдийг ялгаварлан гадуурхах явдал байж болохгүй. Хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх, тэгш эрхийг

хангах талаар тусгай хуулийн заалт үйлчилдэг. Жишээ нь Гэр бүлийн тухай хуулийн 38 дугаар зүйлд албан ёсоор гэр бүлээ бүртгүүлээгүй гэр бүлээс гарсан хүүхдийн эцэг хүүхдийн өмнө үүрэг хүлээхээр заасан. Үүнийг эхийн хүсэлт болон насанд хүрсэн хүүхдийн шүүхэд хандсан хүсэлтийн дагуу шүүх шийдвэрлэж хэрэгжүүлнэ.

142. Монгол Улсын Үндсэн хуульд гадаад явах, оршин суух болон эх орондоо буцаж ирэх нь Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөний нэг бөгөөд энэхүү Үндсэн хуулийн заалт Цагаачлалын тухай хуулиар (1991 он) дамжин хэрэгждэг.

### **Е. Хүчирхийлэл, хайхрамжгүй харьцах, (19 дүгээр зүйл) үүнд бие бялдар болон сэтгэл санааны нь хувьд сэргээн анагаах ба нийгэм дэх байр сууриа дахин эдлэх**

#### **39 дүгээр зүйл**

143. Гэр бүлийн тухай хуулийн 44 дүгээр зүйлд зааснаар хүүхдэд сэтгэл санааны болон бие махбодийн хохирол учруулсан, хүүхдийн нэр төрийг доромжлон харьцсан эцэг, эхэд шүүхийн шийдвэрээр эцэг, эх байх эрхийг нь хасах эсвэл захиргааны шийтгэл ногдуулахаар заасан. Эцэг, эх байх эрхийг нь хасах хэргийг аль нэг байгууллага эсвэл иргэн, харгалзан дэмжигчийн гаргасан мэдүүлгийн үндсэн дээр шүүх шийдвэрлэнэ. Уг хэргийг шийдвэрлэхэд прокурор оролцох ба хүүхдэд тэтгэмж олгох асуудлыг уг шийдвэрээр зохицуулна. Эцэг, эх байх нь хязгаарлагдсан эцэг, эх хүүхдээ халамжлах болон материаллаг хариуцлага хүлээх үүргээс чөлөөлөгдөхгүй.

144. Монгол Улсын Эрүүгийн хуулийн дагуу аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл болон хүүхдийн бие махбод болон сэтгэл санааны хүчирхийллийг гэмт хэрэгт тооцохоор заасан. Үүнд арван зургаан насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх (110 дугаар зүйл), хүчиндэх (112 дугаар зүйл), хүүхдийн тэтгэвэр төлөхөөс болон үр хүүхдээ тэжээн тэтгэхээс ноцтой зайлсхийх (115 дугаар зүйл), сургуулийн өмнөх насны хүүхдийг халамжлах үүрэгт ажилдаа хайнга хандах (121 дүгээр зүйл), асран хамгаалах үүргээ урвуулан ашиглах (120 дугаар зүйл), насанд хүрээгүй этгээдийг гэмт үйл ажиллагаанд татан оруулах (241 дүгээр зүйл) зэрэг гэмт хэргүүд ордог.

145. Монголын хүүхдийн байгууллага энэ чиглэлээр тодорхой зорилго дэвшүүлсэн. Жишээ нь Үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийн хүнд нөхцөл дэх хүүхдүүдтэй холбоотой бүлэгт хохирогч хүүхдийн асуудал тусгагдсан. Бусдын гэм буруутай үйлдлээс хүүхдэд учирсан хохирлыг нөхөн төлөх тогтолцоо бий болгох болон эдгээр хүүхдэд сан байгуулж, тэдгээрийг ослын даатгалд хамруулах талаар заасан.

146. Хүүхдийн байгууллагын нэг гол үүрэг бол гэр бүл дотор эсвэл нийгэмд эрх нь зөрчигдсөн хүүхдийг олж илрүүлэх, асуудлыг холбогдох байгууллагад гаргаж тавих, хохирогч хүүхдийг хамгаалах болон гэм хорыг арилгах арга хэмжээ авах явдал юм. Энэ зорилгоор 1993 онд эцэг, эхчүүдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх “Иргэд эцэг, эхчүүд хүүхдийг өсгөж бойжуулах, хүмүүжүүлэх журам”-ыг боловсруулсан.

## VI хэсэг. Эрүүл мэнд ба хамгаалал

### А. Тахир дутуу хүүхэд

#### 23 дугаар зүйл

147. Конвенцийн заалтад үндэслэн Засгийн газар тахир дутуу хүүхдийг хамгаалах болон үйл ажиллагааны санхүүжилтийг ихэсгэх журам боловсруулсан.

148. Тэтгэврийн тухай хууль (1990 он) тэтгэврийн тогтолцоонд тахир дутуу хүүхдийг бүрэн хамруулах нааштай алхам хийх боломжгүй байна. Хуульд зааснаар төрөлхийн тахир дутуу хүүхэд 16 нас хүрсний дараа нийгмийн даатгалын тэтгэмж авах эрхтэй гэж заасан. Ослын улмаас тахир дутуу болсон тохиолдолд тухайн хүүхэд даатгалд хамрагдсан эсэхээс хамаарч энэхүү даатгалаас тодорхой хэмжээний тэтгэмж авахаар заасан.

149. Ядуу, бага орлоготой өрхөд дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд Хүн амын бодлого болон хөдөлмөрийн яам тахир дутуу хүүхдүүдэд тодорхой хэмжээний тэтгэмж олгодог.

150. 1992 онд тахир дутуу хүүхдүүдийн дунд хийсэн хэсэгчилсэн судалгааг хийхэд, судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 41.7 хувь нь 0–8 насны, 58.3 хувь нь 9–16 насны хүүхдүүд байсан. Тэдгээрийн 53 хувь нь эрэгтэй, 47 хувь нь эмэгтэй байсан бөгөөд 77 хувь нь төрөлхийн тахир дутуу бөгөөд үлдсэн нь зарим нэг нь эмчилгээ хийлгэж байсан. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 55 хувь нь ядуу гэр бүлээс гаралтай эсвэл өнчин хүүхдүүд байсан. Иймээс сүүлийн хоёр жил энэ категорид хамаарах хүүхдэд анхаарал хандуулах болсон. Энэ чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

- а. Хүүхдийн тахир дутууг эрт оношлох, нөхөн сэргээх мэргэшсэн төв байгуулагдсан.
- б. Бие эрхтний хувьд тахир дутуу хүүхдүүдийн тусгай эмчилгээ сувиллалын газар (Улаанбаатар хотын 42 дугаар цэцэрлэг) байгуулсан.
- в. Сонсох, ярих, харах эрхтний согогтой хүүхдэд зориулсан тусгай нөхөн сэргээх ясли байгуулсан. (Улаанбаатар хот)
- г. Сонсох эрхтний согогтой хүүхдүүдийн судалгааны төв
- д. Сонсох эрхтний согогтой хүүхдүүдийг нөхөн сэргээх “Анир” сан
- е. Хүүхдийн харааны судалгааны кабинет
- ё. Оюун ухааны хомсдолтой хүүхдийн судалгааны төвүүд байгуулагдсан.

151. 1986–1991 оны хооронд хийсэн судалгаанаас үзэхэд 18,676 бие эрхтний согогтой болон оюун ухааны хомсдолтой хүүхэд байсан. 1993 онд Баян–Өлгий, Баянхонгор, Булган, Говь–Алтай, Дорнод, Завхан, Хөвсгөл аймаг болон Дархан, Эрдэнэт, Улаанбаатар хотын 15 сургуульд хялбаршуулсан хөтөлбөрөөр 3,800 оюун ухааны хомсдолтой хүүхэд сурч байсан. Архангай, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв болон Ховд аймаг 268 хүүхэд 36 тусгай ангид суралцаж, ерөнхий боловсролын сургуульд 200 гаруй хүүхэд сурч байсан. Улаанбаатар хотын 29 дүгээр тусгай сургуульд сонсох болон харах эрхтний согогтой 521 хүүхэд суралцаж ба тэдгээрийн 201 нь хөдөө орон нутгаас ирсэн. Тахир дутуу хүүхдийг тусгай сургуульд хамруулах нь тун бага байна. Эдгээр тахир дутуу хүүхдэд зориулсан хөтөлбөрийн гол

агуулга нь мэргэшлийн дадлага олгоход чиглэсэн байдаг. Иймээс эдгээр тахир дутуу хүүхдүүдэд боловсрол олгох систем байхгүй гэж хэлж болно.

152. Монголын хүүхдийн байгууллага гэртээ байгаа тахир дутуу хүүхдүүдэд туслах болон олон нийтийн хүч чармайлтыг ашиглах мөн тэдгээр хүүхдүүдэд үзүүлэх эцэг, эхийн халамж, үйлчилгээг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг.

153. ХТҮТ болон НҮБ-ийн Хүүхдийн сан хамтран тахир дутуу хүүхдүүдэд дэмжлэг үзүүлэх төслийг хэрэгжүүлж байна. Түүнчлэн тахир дутуу хүүхдийн өвчнийг эртнээс оношлох болон нөхөн сэргээх талаар тахир дутуу хүүхдүүдийн эцэг, эхэд зориулсан зарим сургалтыг Английн хүүхдийг ивээх сантай хамтран зохион байгуулах гэж байна.

154. Сүүлийн жилүүдэд тахир дутуу хүүхэд бусад хүүхдийн нэгэн адил эрхээ эдлэх боломжийг олгох үүднээс тодорхой арга хэмжээ авсан боловч дараах бэрхшээлүүд тулгарч байна.

- а. Тахир дутуу хүүхэд болон тэдгээрийг асарч буй эцэг, эхэд байнгын тэтгэмж болон дэмжлэг байхгүй байна. Хөрөнгө мөнгөний хувьд тэдэнд наад захын хэрэгцээгээ хангах баталгаа байхгүй байна.
- б. Тахир дутуу хүүхдийн хувьд тэдгээрийг эмчлэх болон боловсрол олгоход тусгайлан анхаарч хандах ёстой гэсэн нийтлэг хандлага байна.
- в. Нөхөн сэргээх талаарх эцэг, эхчүүдийн мэдлэг, ур чадвар хангалтгүй байна.
- г. Тахир дутуу хүүхэдтэй ажиллах эмч, багш нарыг мэргэшүүлэх үндэсний байгууллага байхгүй байна.
- д. Дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд санхүүгийн бэрхшээл тулгарч байна.

155. Эдгээр бэрхшээлийг даван туулах арга замууд:

- а. Тахир дутуу хүүхдэд чиглэсэн тусгай дэмжлэг, тэтгэмжийг хуульчлах
- б. Эртнээс өвчнийг оношлох болон нөхөн сэргээх талаар эцэг, эх, эмч нарт сургалт явуулах
- в. Тахир дутуу хүүхэд бусад хүүхдийн нэгэн адил гэр бүл дотроо өсөж бойжих нөхцлийг хангах болон тахир дутуу хүүхдийг дэмжих хэрэгцээ шаардлагын талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх
- г. Тахир дутуу хүүхдийг мэргэжлийн сургалтад хамруулах, ажлын байр бий болгох эх үүсвэр бий болгох
- д. Эдгээр хүүхдэд шаардлагатай тусгай аппарат хэрэгсэлийн нийлүүлэлтийг сайжруулах.

## **Б. Эрүүл мэнд ба эрүүл мэндийн үйлчилгээ**

### **24 дүгээр зүйл**

156. Монгол Улсын Үндсэн хууль (1992 он), Эрүүл мэндийн тухай хууль (1977), Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар хүүхдийн эрүүл мэнд, тэдгээрийн амьдрах, амьд явах, эрүүл мэндийн үйлчилгээг үнэ төлбөргүй хүртэх эрхийг яс үндэс, хэл, хүйс, оршин суугаа газраас үл хамааран аливаа ялгаваргүйгээр эдлэхийг хуульчилсан. Эрүүл мэндийн статистикийн мэдээллийн тогтолцоо нь хэрэгжилтийг хянах үүрэгтэй. Сумын эрүүл

мэндийн ажилтнууд энэ үүргийг хариуцах бөгөөд томоохон клиникийн хувьд статистикийн хэлтэс хариуцдаг. Эдгээр хэлтсүүд сар болгон хот, аймгуудаас төрөлт, нас баралт болон халдварт өвчний талаар мэдээлэл цуглуулж Үндэсний статистикийн газарт дамжуулдаг.

157. 1990–1993 онд хүүхдийн эрүүл мэндэд нөлөөлж буй хэд хэдэн хүчин зүйлүүдийг харьцуулсан статистик:

<b>Он</b>	<b>1990</b>	<b>1993</b>
Нярай хүүхдийн эндэгдэл (1000 амьд төрөлт тутамд)	63.4	57.4
5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл (1000 амьд төрөлт тутамд)	87.0	82.7
Төрөлт	35.6	22.8
Нас баралт	7.9	7.5
Эхийн эндэгдэл (1000 эх тутамд)	1.2	2.4

Харьцуулалт: нярайн эндэгдэл болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл буурч, харин эхийн эндэгдлийн түвшин ихэссэнийг харуулж байна.

158. Хүүхдийн эндэгдлийг бууруулах эрүүл мэндийн нэгдсэн сүлжээ ажиллаж байна. Монгол Улсын засаг захиргааны нэгж бүр хүүхдэд мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн ажилтан, эмч, хүүхдийн эмч болон бусад хэрэглэгдэхүүнээс бүрдсэн эрүүл мэндийн байгууллагатай. Багийн эмнэлгүүдэд хүүхэд хэвтэх зориулалтын тусгай ор байхгүй ба сумын түвшинд хүүхэд хэвтэх ор бүхий эмнэлэгтэй бөгөөд аймгийн түвшинд хүүхдийн тусгай тасаг, 30–120 хүүхдийн ор бүхий эмнэлэгтэй. Улаанбаатар хотод 200–300 ортой 4 хүүхдийн эмнэлэг, 840 ор бүхий эрдэм шинжилгээний төв ажиллаж байна. Анагаах ухааны их сургуульд хүүхдийн эмч нарт зориулсан тусгай факультеттай.

159. Нярайн эндэгдлийн гол шалтгаан нь уушиг, амьсгалын замтай холбоотой ба энэ нь нийт нярайн эндэгдлийн 75 хувийг, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 54.2 хувийг эзэлж байна. Энэ түвшин сүүлийн 20 жилд тогтвортой байна. Нөлөөлж буй хүчин зүйлд эх газрын хэт хүйтэн цаг агаар, орон байрны хүрэлцээгүй байдал, ам бүл олонтой айл, тэжээлийн дутагдал, тээвэр, холбоо зэрэг дэд бүтэц муу хөдөө орон нутагт тархай бутархай байдлаар амьдарч буй хүн ам, эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээний хүрэлцээ хангалтгүй гэх мэт. Бусад орнуудтай харьцуулахад Монгол Улс дахь нярайн эндэгдлийн голлох шалтгаан нь улаан бурхан биш байна. Сүрьеэ өвчин ихсэж байгаа тухай мэдээлэл байгаа боловч нөхцөл байдлыг бодитойгоор тодорхойлох судалгаа хийгдээгүй байна.

160. Одоогийн нөхцөл байдлыг харгалзан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- а. Шинээр батлагдах Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөлд хүүхдийн эрүүл мэндийн талаарх Засгийн газар, шүүх, боловсролын байгууллагууд болон аж ахуйн нэгжүүдийн хүлээх үүрэг хариуцлагыг тусгах
- б. Хүүхдийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаарх эцэг, эхийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, энэ чиглэлээр сургалт зохион байгуулах



в. Нярайн эндэгдэл өндөр байгаа нь Монгол Улсын эрүүл мэндийн нөхцөл байдлыг тодорхойлж байна. Өнгөрсөн онд Улаанбаатар хотын 16 эрүүл мэндийн төвүүдийн дунд “Эрүүл хүүхэд” үзлэгийг зохион байгуулахад 600 хүүхэд тутмын 1 нь л цоо эрүүл байгаа нь харагдсан. Энэ нөхцөл байдал сургуулийн насны хүүхдүүдийн дунд илүү хүнд байна. Хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлд тэнэмэл болон хаягдсан хүүхдүүд, хүүхдийн эрхэлж буй хүнд хөдөлмөр, биеэ үнэлэлт, архи уух, тамхи татах болон бусад муу зуршлууд, сургууль завсардалт, ядуу өрхийн тоо болон хоол хүнсний хомсдол нөлөөлж байна.

161. Эцэг, эхийн хүүхдийн өмнө хүлээх хариуцлага буурсантай холбоотойгоор хүүхдийн эрүүл мэндийн байдал муудаж байна. Түүнчлэн бие махбодын хувьд тахир дутуу болон оюун ухааны хомсдолтой хүүхдийн тоо өндөр хэвээр байна.

162. Эрүүл ахуйн нөхцөл муу байгаагаас шалтгаалан сүүлийн гурван жилд хамуу, халдварт өвчний өвчлөлийн түвшин ихэссэн. Иймээс хүүхдэд бага наснаас ариун цэвэрч байх талаар сургалт явуулах хэрэгцээ шаардлага бий болоод байна.

163. Санхүүгийн асуудлыг шийдвэрлэх тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Түүнчлэн шилжилтийн үеийн эдийн засагтай холбоотойгоор бусад олон асуудлууд тулгарч байна. Хувийн эмнэлгийн чиглэлээр хийх шаардлагатай олон зүйл байна.

164. Түүхийн хувьд Монголууд “тархи хөдлөх” зэрэг өвчнүүдийг уламжлалт аргаар эмчилдэг байсан. Гэвч олон тохиолдолд буруу оношилж хүүхдүүд эндэх явдал гардаг байсан. Мэдээлэл түгээх, хүмүүсийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, хувийн эмч нарт гэрчилгээ олгох зэрэг нөхцөл байдлыг сайжруулах тодорхой арга хэмжээ авсан. Хүүхдийн эрүүл мэнд болон хоол, тэжээлийн талаар судалгаа хийж, Монгол Улс дахь эрүүл мэндийн статистик мэдээллийг цуглуулах талаар дорвитой ажлууд хийгдэж байна.

### **Жирэмсний болон амаржсаны асрамж**

165. Эхчүүд бүтэн цалинтайгаар төрөхөөс өмнө 45 хоногийн болон төрсний дараа 56 хоногийн жирэмсний болон амаржсаны амралт авах эрх эдэлж байна.

166. 1989 оны байдлаар, 287 амаржих газар байсан. Харин 1992 оны байдлаар эдгээр амаржих газрын тоо 56 болтлоо буурсан. Эрүүл мэндийн сайдын 1993 оны 39 тоот тушаалаар сумын эмнэлгийн нэг өрөөг эхчүүдэд зориулж, төсвөөс санхүүжүүлэхээр тогтоосон. 1993 онд эдгээр газрын тоо 147 хүрч 263 өрөөг ашиглаж байв. 1993 онд нийт 3,650 эхчүүдийн 1,913 нь амаржих газар хэвтсэн байна.

167. НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран бүх жирэмсэн болон цус багадалтай эхчүүдэд төмрийн бэлдмэл өгч байна. Бүх сумын эмнэлгүүдэд гемоглобин өгсөн. Цус багадалтаас урьдчилан сэргийлэх гарын авлага боловсруулж аймаг болгонд тараасан.

168. Эхийн эндэгдлийг бууруулах талаар:

- а. Сум болон аймгийн амаржих газруудыг тусгай эм тариа болон багаж хэрэгслээр хангах арга хэмжээг хоёр удаа авч хэрэгжүүлсэн
- б. Сум болон аймгийн эмнэлгийн эмч, эх баригч болон асрагч нарт эх барихын сургалт зохион байгуулсан

- в. Гэр бүл төлөвлөлт, жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх, эхийн эндэгдлийг бууруулах талаар лавлах материал болон эх барих талаар гарын авлага бэлтгэж, тараасан
- г. Улирал тутам “Эсэн мэнд амаржихуй” сэтгүүл бэлтгэж, тараасан
- д. Орон нутагт гэр бүл төлөвлөлтийн төслийн таван бүсийн зохицуулагч ажиллаж байна.
- е. Нярай хүүхэд болон эхчүүдэд үзүүлэх наад захын тусламж эмчилгээний талаар НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

169. Одоогийн байдлаар нийт төрөлтийн 98,8 хувь нь амаржих газар, 2.2 нь гэрт төрж байна.

### Хүүхдийн тэжээлийн байдал

170. 1992 оноос хойш 0–3 насны хүүхдэд өгч буй уураг, эрдэс болон бусад төрлийн амин дэмийн талаар судалгаа хийгдсэн. Хүүхдийн жин, тэдний тэжээлийн болон эрүүл мэндийн байдалд халдвар судлалын судалгаа хийгдсэн. 1992 онд энэ судалгааг 3 хот, 4 аймаг, 16 сумын 0–5 насны 1,560 хүүхэд, 1993 онд 1 хот, 8 аймаг, 32 сумын 5,547 хүүхдийг хамруулан хийсэн. 1993 оны судалгаагаар судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 35 хувь нь тэжээлийн дутагдалтай, 32.7 хувь нь цус багадалтай байв.

171. Гемоглобин стандартад түшиглэн эдгээр аймгуудын 5 хүртэлх насны хүүхдүүд болон жирэмсэн эмэгтэйчүүдэд тусгай үзлэг хийсэн бөгөөд Улаанбаатар хотын 0–5 насны 4,080 хүүхдүүд өсөлтийн стандартын үзлэгт хамрагдсан.

172. 13 аймаг, 2 хотод тусгай санал асуулгын хуудсаар хөхөөр хооллох талаар судалгаа явуулсан бөгөөд 0–24 сартай 6,620 хүүхэд энэ судалгаанд хамрагдсан.

173. Хүүхдийн хоол боловсруулах газар хүүхдэд зориулж 13 төрлийн хоол бэлтгэдэг бөгөөд 5–6 хоолны цэсийг шинээр нэмсэн.

174. 0–1 настай хүүхдийн хоол тэжээлийн байдалд судалгаа хийсэн. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд, “нярай хүүхдийн хоол”, “хоолны орц”, “хөхүүл эхийн сүүний чанарыг сайжруулах арга”, “3 хүртэлх насны хүүхдийн хоолны талаарх зөвлөгөө” зэрэг гарын авлагыг боловсруулсан.

175. 1992 онд НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран 17 аймаг, бүх сумд болон 3 хотын эмч, эх баригч болон хүүхдийн эмч нарт хөхөөр хооллолтын талаар сургалт явуулсан. Бид хөхөөр хооллохыг хөхүүлэн дэмжих талаар тодорхой амжилтад хүрсэн. Дөнгөж шинээр төрсөн хүүхдийг эхээс нь тусгаарладаггүй. Хагалгаагаар төрсөн хүүхэд төрснөөс хойш 1–2 цагийн дараа эхийнхээ сүүг хөхдөг. Хүүхдийг 4–6 сар хүртэл хөхөөр хооллох хатуу журам үйлчилдэг бөгөөд амаржих газруудад түүнийг орлох өөр хоол, тэжээл байдаггүй. НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран бүсийн болон орон нутгийн нэгжийн хэмжээнд 625 эмч, эмнэлгийн ажилтнуудыг оролцуулсан “Хүүхдийг хөхөөр хооллох болон хүүхдэд ээлтэй эмнэлэг” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. 1993 оны 6 дугаар сард НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран “Хүүхдийг хөхөөр хооллох болон хүүхдэд ээлтэй эмнэлэг” чиглэлээр мэргэшсэн 25 хүнийг бэлтгэсэн. Жил бүрийн 8 дугаар сарын 1–8-ны өдрүүдэд үндэсний хэмжээнд “Хүүхдийг хөхөөр хооллох долоо хоног”-ийг тэмдэглэн өнгөрүүлдэг. Энэ долоо

хоногийн хугацаанд, хүүхдийг хөхөөр хооллохыг хөхүүлэн дэмжсэн төрөл бүрийн үйл ажиллагааг зохион байгуулдаг бөгөөд НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр “Эхийн сүү” сэтгүүлийг улирал тутам хэвлэн гаргадаг. 1993 онд НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр доктор С. Вирапон “Хүүхдийг хөхөөр хооллох болон хүүхдэд ээлтэй эмнэлэг” чиглэлээр мэргэшсэн 15 боловсон хүчнийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлсэн.

### Ундны ус

176. Ундны усны чанарыг дээшлүүлэх дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.
- а. Үндэсний хэмжээнд ундны ус болон өдөр тутмын хэрэглээний усанд тавигдах хоёр тусгай шалгуурыг боловсруулсан. Энэхүү хоёр шалгуурын дагуу засаг захиргааны удирдлага усны чанарыг тодорхойлох химийн анализ хийсэн
  - б. Эрүүл мэндийн яам болон Байгаль орчны яам ундны усны эх үүсвэрийг хамгаалах тусгай журам боловсруулсан
  - в. Ундны усны чанарын талаар сургалт явуулах 20 сургагч багш бэлтгэгдсэн
  - г. Ундны усны чанарыг хянах сургалт зохион байгуулагдсан
  - д. Усаар хангах үндэсний систем бий болсон.
177. Үзлэг шалгалтын үндсэн дээр Засгийн газарт усны хангалт болон ариун цэврийг сайжруулах саналыг боловсруулж, өргөн барина.

### В. Нийгмийн даатгал, хүүхэд халамжийн үйлчилгээ болон хэрэглэгдэхүүн

#### 26 дугаар зүйл

178. Монгол Улсын шинээр батлагдсан ихэнх хууль тогтоомжуудад хүүхдийн нийгмийн даатгал болон тэдний асрамжийн асуудал тусгагдсан.
179. Тэтгэмжийн тухай хуулиар дараах тэтгэмжийг хүүхдэд олгохоор заасан.
- а. Хүүхэд асарсны тэтгэмж. Өрхийн сарын орлого нь 1,200 төгрөгөөс доогуур бол хүүхэд төрснөөс хойш гурван сарын дараа хүүхэд асарсны 440 төгрөг, ихэр бол 600 төгрөгийн тэтгэмж авах;
  - б. Олон хүүхэдтэй өрхийн тэтгэмж. Дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй өрхийн хүүхэд тус бүр (0–3 настай бол 100 төгрөг, 4–7 настай бол 250 төгрөг, 8–16 настай бол 450 төгрөг) тэтгэмж авна;
  - в. Ихэр хүүхдийн тэтгэмж. Хоёр хүртэлх насны ихэр хүүхдүүдийг асарч буй эх тэтгэмж авах эрхтэй;
180. Тэтгэврийн тухай хуулиар:
- а. Тахир дутуугийн тэтгэвэр. 16 насанд хүрсэн тахир дутуу иргэн бүр тахир дутуугийн тэтгэвэр авах эрхтэй. Сард авах тэтгэврийн дээд хэмжээ 200 төгрөг, доод хэмжээ 120 төгрөг;
  - б. Тэжээгчээ алдсаны тэтгэвэр. Тэжээгчээ алдсан 16 насанд хүрээгүй хэн боловч тэтгэвэр авах эрхтэй. Тэтгэврийн хэмжээг тухайн хүүхдийн нөхцөл байдлаас хамаарч тогтооно;
181. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар 16 насанд хүрээгүй хүүхэд бүр

(ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа бол 18 нас хүртэл) төрийн зардлаар эрүүл мэндийн даатгалд хамрагдах боломжийг олгосон.

182. Боловсролын тухай хуульд хүн бүр 18 нас хүртлээ улсын зардлаар суурь боловсрол эзэмшихийг хуульчилсан.

183. Дээрх хуулиар тогтоосон мөнгөний хэмжээ өнөөгийн үнэ, инфляцийн өндөр түвшин дэх хүнд хэцүү нөхцөлд хүүхдийн наад захын хэрэгцээ, шаардлагыг хангаж чадахгүй байна. Шилжилтийн үеийн хүнд хэцүү үеийг харгалзан Монгол Улсын Засгийн газар Ядуурлыг бууруулах хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээг авч байна. Түүнчлэн Засгийн газрын мөрийн хөтөлбөрт хүмүүсийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн иж бүрэн арга хэмжээг төлөвлөсөн. Үнэ огцом өсөж байгааг харгалзан Засгийн газар инфляцийн түвшинтэй тохируулан цалин, тэтгэвэр, тэтгэмжийг индексжүүлэх системийг нэвтрүүлсэн. Түүнчлэн ядуу, бага орлоготой, олон хүүхэдтэй өрх, болон ганц бие өрх толгойлсон өрхүүдэд боломжоороо шаардлагатай дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авч байна. Түүнчлэн ядуу хүмүүст нийгмийн туслалцаа, дэмжлэг үзүүлэх тодорхой арга хэмжээнүүд Засгийн газрын хэд хэдэн тогтоол, шийдвэрт тусгалаа олсон. Түүнчлэн Засгийн газар бизнес эрхлэх чадвартай ядуу хүмүүст хөнгөлөлттэй зээл олгох, харин бие даан амьдрах чадваргүй хүмүүст үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлж байна. Засгийн газар туслалцаа шаардлагатай хүүхдүүдийн 20 хувийг хамарч буй асрамжийн газар болон хандивын цэцэрлэгийг санхүүжүүлж байна. Нийгмийн эмзэг бүлгийн нийгмийн асуудлыг нийгмийн хүч чармайлтыг дайчлахгүйгээр шийдвэрлэх боломжгүй юм. Иймээс энэ зорилгоор ТББ-ууд болон хувийн аж ахуйн салбарын үүрэг, оролцоо чухал болж байна.

184. Гэвч эдгээр хүүхдүүдэд олгож буй дэмжлэг, туслалцаа нь тэдний амьдралын баталгаа биш юм. Энэ нь тэдний зөвхөн амь зогоох наад захын хэрэгцээг хангаж байна. Иймээс холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт хийж, Улсын Их Хуралд өргөн барих гэж байна. Нийгмийн даатгалын асуудлыг хариуцсан бие даасан байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь Монгол Улсын засаг захиргааны нэгж бүрт салбартай.

185. Тулгарч буй бэрхшээлүүд:

- а. Монгол Улсын шинэ нөхцөлд хуучин хууль тогтоомжийн заалтууд нийцэхгүй байна.
- б. Хүмүүс “намайг хоолло, надад тусал” гэсэн хуучин сэтгэлгээгээр амьдарч, хөдөлмөр эрхлэх сонирхолгүй байна.
- в. Шилжилтийн үеийн эдийн засгийн бэрхшээлээс хамаарч олон хүүхэдтэй өрхүүд ядуу хүмүүсийн тоонд орж байна.
- г. Эдгээр хүмүүст туслах Засгийн газрын хөрөнгө нөөц, бололцоо хомс байна

186. Асуудлыг шийдвэрлэх арга зам:

- а. Нийгмийн даатгал, тэтгэмжийн талаар хууль боловсруулах;
- б. Хөдөлмөр эрхлэх боломжтой иргэдэд ажлын байр бий болгох, үр хүүхдээ өсгөж хүмүүжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- в. Асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй хүүхдийг төрийн хамгаалалтад авах;
- г. Нийгмийн даатгалын сан байгуулахад ТББ-ууд болон хувийн хэвшлийнхний хувь нэмрийг оруулах;

## VII хэсэг. Боловсрол, чөлөөт цаг болон соёлын арга хэмжээ

### A. Боловсрол

#### 28 дугаар зүйл

187. Монгол Улсад хүүхдийг хөгжүүлэхэд чиглэсэн иж бүрэн боловсролын тогтолцоо үйлчилж байна. Энэ асуудал Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын тухай хууль болон Боловсролын хөгжлийн талаарх бодлогод тусгагдсан.

188. Боловсролын тухай хуульд Монгол Улсын иргэн бүр боловсролын бүх түвшин, курсэд төлбөртэй болон төлбөргүйгээр оролцох эрхтэй бөгөөд 17 нас хүртлээ суурь боловсрол эзэмших нь хүн бүрийн үүрэг гэж заасан. Хуулийн 3 дугаар зүйлд боловсрол төрийн хяналтад дор байх бөгөөд Монгол Улсын иргэн бүр төрөлх хэлээрээ сурч боловсрох эрхтэй гэж заасан.

189. Боловсролын бодлогыг ардчилах болон уян хатан, чөлөөт боловсролын тогтолцоо бий болгох бодлого хэрэгжсэн. Боловсролын бодлого нь соёл уламжлал болон тухайн ард түмний өвөрмөц онцлогтой уялдаатайгаар шинэчлэгдэх ёстой. Энэхүү процессын гол зорилго нь хүүхэд өөрийгөө чөлөөтэй илэрхийлэх, бусдын ашиг сонирхлыг хүндэтгэх, нийгэмд өөрийн байр сууриа эзлэх орчин нөхцлийг бүрдүүлэх явдал юм.

190. Монгол Улсын Засгийн газар ядуу өрхийн хүүхдийг халамжийн цэцэрлэгт хамруулах өнчин хүүхдийг асрамжийн газар байрлуулах, малчдын хүүхдэд зориулсан сургуулийн дотуур байр ажиллуулах, тахир дутуу болон оюуны хомсдолтой хүүхдийг тусгай сургуульд хамруулах зэргээр хүүхэд гэр бүлдээ өсөж бойжих, суурь боловсрол эзэмших таатай орчинг бүрдүүлэхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлж байна. Бүх аймаг, хотууд халамжийн цэцэрлэгтэй бөгөөд малчин өрхийн хүүхдүүдийн 80 орчим хувь нь сургуулийн дотуур байранд байна. Гэвч сүүлийн жилүүдэд санхүүгийн бэрхшээлээс хамаарч тэдгээр байгууллагуудын тоо багассан. Тусгай сургуульд хамрагдах ёстой хүүхдүүдийн зөвхөн 10 хувь нь хамрагдсан байна. Нийгмийн эмзэг бүлгийн хүүхдэд суурь боловсрол эзэмшүүлэх болон мэргэжлийн сургалт зохион байгуулахад чиглэсэн тусгай хөтөлбөр, төслүүдийг боловсруулсан. Одоогийн байдлаар хүүхдүүдэд 10 төрлийн тусгай мэргэжил эзэмшүүлэх нэг мэргэжлийн төв үйл ажиллагаа явуулж байна.

191. Монгол Улсын боловсролын бодлогын зорилго нь хүүхэд ур чадвар, авьяасаа хөгжүүлэх болон эх орон, хэл, соёл уламжлал болон соёл иргэншлийг хүндэтгэх хүмүүнлэг ёсонд сургахад чиглэгдэнэ.

192. Хүүхдүүд хүйснээс үл хамааран аливаа ялгаварлан гадуурхалтгүйгээр бие бялдар болон оюун ухаанаа хөгжүүлэх хэрэглэгдэхүүнийг тэгш эрхтэйгээр ашиглаж байна.

193. Сүүлийн жилүүдэд иргэдэд учирч буй эдийн засгийн бэрхшээлээс хамаарч сургууль завсардалтын тоо ихсэж байна. Сургууль завсардсан хүүхдүүдийн ихэнх нь эрэгтэй хүүхэд байх ба энэ нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэл болон эрэгтэй хүүхдүүдийн хөдөлмөрлөх чадвартай холбоотой байж болох юм. Сургууль завсардсан хүүхдүүдэд чиглэсэн олон төрлийн үйл ажиллагааг зохион байгуулсан.

194. Одоогийн байдлаар сургуулийн өмнөх насны нийт хүүхдүүдийн дөнгөж 20

хувь нь цэцэрлэгт хамрагдаж байгаа бөгөөд малчин өрхийн хүүхдийг сургуульд бэлтгэх тогтолцоо байхгүй байна. Ойрын ирээдүйд ийм тогтолцоо байгуулах талаар анхаарч ажиллана.

195. Үндэстний цөөнх болох казах иргэд үр хүүхдээ төрөлх хэлээрээ сургах боломжоор хангагдсан. Баян-Өлгий болон Ховд аймгуудад хэд хэдэн казах сургуулиуд байдаг.

196. 1994 онд улсын төсвөөс 15.3 тэрбум төгрөг буюу нийт төсвийн 16.1 хувийг боловсролын салбарт хуваарилсан. Үүнээс 60 хувийг ерөнхий боловсролд зарцуулдаг. Энэхүү санхүүжилтийн 56.4 хувийг дулаан, цахилгаан болон ус, 37.5 хувийг цалин хөлс, 13.3 хувийг захиргааны зардалд зарцуулсан. Өрхөөс нэг хүүхдэд нэг жилд зарцуулах зардал ойролцоогоор 100 орчим америк доллар байдаг. Энэ нь ядуу өрх болон улсын төсөвт байгууллагад ажилладаг эцэг, эхчүүдийн хувьд тийм ч бага биш мөнгө юм. Иймээс эдгээр өрхийг нийгмийн даатгалын сүлжээ, шимтгэлд хамруулж улмаар хүүхдээ сургуульд хамруулах боломж олгох шаардлагатай байна.

197. Багш нарын тоо хүрэлцээгүй байна. Дор хаяж 3,000 багш, ялангуяа математик, физик, хими болон гадаад хэлний багш нар шаардлагатай байна. Багш нарыг бэлтгэх бодлого нь олон төрлийн ур чадвар бүхий багш нарыг бэлтгэхэд онцлон анхаарч байна. Багш нарыг бэлтгэх байгууллагуудын хувьд нэг их сургууль, 4 коллеж, 1 хувийн сургууль үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр сургуулиудыг жил бүр 1,000 хүн төгсдөг боловч зөвхөн 70 гаруй хувь нь мэргэжлээрээ ажилладаг.

## **Б. Чөлөөт цаг, амралт болон соёлын арга хэмжээ**

### **31 дүгээр зүйл**

198. Монгол Улсын Үндсэн хуулийн “иргэд амрах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах өөрийгөө хөгжүүлэх, соёлын үйл ажиллагаа эрхлэх” эрхийн талаарх заалт хүүхдийн хувьд хууль зүйн баталгаа болдог. Монгол Улс энэ зорилгод чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах талаар тодорхой хэмжээний туршлага хуримтлуулсан. Жил болгон хүүхдэд чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаануудыг аймаг, хот, сум, багийн түвшинд тодорхой төлөвлөсөн төлөвлөгөөний дагуу зохион байгуулдаг.

199. Хүүхдийн байгууллагууд ийм чиглэлийн үйл ажиллагаа явуулах хангалттай материаллаг баазтай. Одоогийн байдлаар Монгол Улсад хүүхдийг өөрийгөө хөгжүүлэхэд нь туслах зорилготой 18 ордон, соёлын төвүүд, 33 зуслан, 10 дээш тооны гадаад хэл, шинжлэх ухааны болон байгаль орчин хамгааллын тусгай сургалтын төвүүд үйл ажиллагаа явуулж байна. Монголын хүүхдийн төлөө төв нь Монголын Хүүхдийн ордон, Олон улсын хүүхдийн амралтын төв, Хүүхдийн урлан бүтээх төв зэрэг харьяа байгууллагуудтай. Эдгээр байгууллагууд 4,000–21,000 хүүхдүүдийн чөлөөт цагт зориулж соёл, спорт, урлагийн үйл ажиллагаа явуулдаг. Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийн ойролцоогоор 30 гаруй хувь нь хичээлээс гадуур ийм төрлийн үйл ажиллагаанд хамрагддаг.

200. 1990 оноос өмнө хүүхдийн чөлөөт цагт зориулсан үйл ажиллагааны иж бүрэн

тогтолцоо үйлчилж байсан гэж хэлж болно. Гэвч улс төр, эдийн засгийн шинэчлэл, Монгол Улсын засаг захиргааны нэгжийн өөрчлөлт, төрийн байгууллагын бүтцийн шинэчлэлт зэрэг нь тэдгээрийн үйл ажиллагаа, бүтцэд тодорхой өөрчлөлт оруулсан. Өмч хувьчлалтай холбоотойгоор сүүлийн 3 жилд соёлын клубүүд, номын сан, кино театрууд, биеийн тамирын заал болон музей зэрэг хаагдаж, хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах зорилготой байгуулагдсан байгууллагууд үндсэн үйл ажиллагааны чиглэлээ өөрчилсөн. Үүний үр дүнд чөлөөт цагт зориулсан үйл ажиллагаанд хамрагдах сурагчдын тоо эрс буурсан. Эдгээр үйл ажиллагаанд хамрагдах хүүхдүүдийн тоо буурсан нь бүх курс, үйл ажиллагаанд төлбөр, хураамж бий болсонтой нягт холбоотой. Зах зээлд борлогдох үйлдвэрлэл явуулах шинэ шаардлага бий болоод байна. Иймээс олон сургуулиуд шаардлагатай материалаар хомс байна.

201. Хэрэгжүүлэх ажил:

- а. Хүүхдэд зориулсан чөлөөт цаг болон соёлын арга хэмжээ явуулдаг байгууллагын үйл ажиллагааг дэмжих;
- б. Хүүхдийн хөгжилд зориулах эх үүсвэрийг нэмэгдүүлэх;
- в. Хүүхдийн нас, онцлог тохирсон тусгай хөтөлбөрийг боловсруулах (жишээ нь, сургуулийн өмнөх насны хүүхдэд хэл ярианы ур чадвар болон бие бялдрын хөгжлийг хангахад чиглэсэн үйл ажиллагаа);
- г. Өсвөр үеийнхний үзэл бодол, саналаа илэрхийлэх, ур чадвараа илтгэн гаргах чадварыг нь хөгжүүлэх;
- д. Ахлах насныхныг мэргэжлийн дадлага, амьдралын арга ухаанд сургах гэх мэт
- е. Конвенцийн хүүхдийг шинжлэх ухааны үндэстэйгээр хөгжүүлэх тухай заалтыг хэрэгжүүлэх боловсон хүчнийг бэлтгэх, сургах.

## **В. Боловсролын зорилго**

### **29 дүгээр зүйл**

202. 1991 оны 7 дугаар сарын 18-ны өдөр Боловсролын сайдын баталсан бодлогод боловсрол нь улс орны хөгжлийн гол цөм нь байх бөгөөд сургалтын хөтөлбөрийн бүтэц, зохион байгуулалт, агуулга нь хүүхдэд үндэсний соёл уламжлал, үнэт зүйл болон хүн төрөлхтний соёл иргэншлийн талаар мэдлэг олж авах болон өөрсдийн онцлог авьяасыг хөгжүүлэх боломж олгоход чиглэж шинэчлэгдэнэ.

203. Монгол Улсын боловсролын тогтолцоо 4 хэсгээс бүрддэг. Сургуулийн өмнөх шатны байгууллага, ерөнхий боловсролын бага болон дунд сургуулиуд, мэргэжлийн сургуулиуд мөн шинжлэх ухааны судалгааны байгууллагуудад хуваагддаг. Эдгээр боловсролын байгууллагууд тус бүр өөрийн онцлогтой. Сургуулийн өмнөх шатны байгууллагад 3–8 насны хүүхэд хамрагддаг. Ерөнхий боловсролын сургуулиуд (6 жил) 8 жил, мэргэжлийн сургалт олгох зорилготой 10 жил эсвэл 9 жил зэрэгт хуваагддаг.

204. Сургуулийн гол зорилго бол суурь боловсрол олгох явдал юм. Сургууль хүүхдийг мэргэжлээ сонгох болон насанд хүрэгчдийн амьдралд бэлтгэх суурийг нь тавьж өгдөг. Мэргэжлийн сургуулиуд нь суурь боловсрол эзэмших хэрэглэгдэхүүн олгохоос гадна хүүхдэд тодорхой ажил мэргэжилтэй холбоотой ур чадвар эзэмшүүлэхэд чиглэдэг.

10 жил суралцах нь хүүхдүүд суурь боловсролоо бэхжүүлэх, цаашид ажиллах тодорхой салбарыг сонгох боломжийг олгоно. Нэн тэргүүний зорилт бол боловсролын бүтцийг (6+2+2) байдлаар зохион байгуулж хүүхдэд суурь боловсрол эзэмшүүлэх явдал юм.

205. Ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрийг дараах зарчмууд дээр үндэслэн боловсруулсан.

- а. Үндэсний соёл уламжлал болон үнэт зүйлст тулгуурлан хүүхдийн хүн төрөлхтний соёл иргэншлийн талаарх мэдлэгийг баяжуулах;
- б. Боловсролд нөлөөлж буй улс төр, үзэл суртлыг арилгах;
- в. Шинжлэх ухаан, технологи, эдийн засгийн ололт амжилтыг үр бүтээлтэйгээр нэвтрүүлэх;
- г. Онол, практикийг хослуулах;
- д. Хүүхдийн насны онцлогт тохирсон тогтолцоог нэвтрүүлэх;
- е. Сургалтын орчин үеийн технологийг нэвтрүүлэх;
- ё. Монголын үндэсний бичгээр сургалт явуулах арга барилыг боловсруулах, хэрэгжүүлэх;
- ж. Орчин үеийн техник хэрэгсэл болон бусад сургалтын хэрэглэгдэхүүнийг өргөнөөр ашиглах;

206. Хүүхдийн авьяасыг эртнээс хөгжүүлэх, гоц авьяастай хүүхдүүдийн тусгай сургууль байгуулахад онцгой анхаарал хандуулж байна. Хүүхэд болон эцэг, эх хүүхэддээ хамгийн тохиромжтой сургуулийг сонгох эрхтэй.

207. Конвенцийн энх тайвныг сахих, нэр хүндээ хамгаалах, тэвчээртэй байх, эрх чөлөө, тэгш эрх, эв санааны нэгдлийг эрхэмлэх үзэл санаагаар хүмүүжүүлэх, чөлөөт нийгэмд хүүхдүүд хариуцлагатай амьдрахад бэлтгэх, ахмадууд, байгаль орчин, соёл уламжлал, үнэт зүйлс зэргийг хүндэтгэх зэрэг гол заалтууд сургуулийн хөтөлбөрт хангалттай тусгагдсан. Түүнчлэн хүүхдүүд олон байгууллагын гишүүнчлэлээр дамжуулж өөрсдийн эрхээ эдлэх боломжоор хангагдсан. Жишээ нь “Миний эрин үе” байгууллага гишүүддээ дараах уриаг дэвшүүлсэн.

- Эх орон, ард түмнээ хайрлах;
- Хэрхэн амьдрах талаар суралцах;
- Бие махбод болон оюун ухааны хувьд ариун, эрүүл байх;
- Монголын хууль тогтоомжийг биелүүлэх;
- Дэлхийн бүх хүүхдийн эв нэгдлийг хангах.



## **VIII хэсэг. Тусгай хамгаалалтын арга хэмжээ**

### **А. Онцгой нөхцөл дэх хүүхдүүд**

#### **22–38 дугаар зүйлүүд**

208. Монгол Улсад дүрвэгч хүүхдийн асуудал нийтлэг асуудал биш юм. Гэхдээ Монгол Улсын Үндсэн хуульд гадаадын дүрвэгсдийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсад оршин суух боломжийг олгосон. Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай хуульд (1993 он) цагаачлал хүссэн хүнд цагаачлал хүссэн шалтгаан нь Монгол Улсын бодлогод нийцэж байвал улс төрийн орогнол олгоно гэж заасан. Дүрвэгсдийн эрх зүйн байдлын талаарх эцсийн шийдвэрийг Монгол Улсын Ерөнхийлөгч гаргана.

209. Дээрх хуулийн 7 дугаар зүйлд бага насны хүүхэд зөвхөн эцэг, эх болон асран хамгаалагч харгалзан дэмжигчийн хамт гадаадад зорчих болон цагаачилна гэж заасан. 16–18 насны хүүхэд эцэг, эхтэйгээ цагаачлах тохиолдолд тухайн хүүхдийн бичгэн зөвшөөрөл шаардлагатай. Бичиг баримтын хувьд гэвэл хүүхэд гадаад оронд зорчих паспорт авах эсвэл эцэг, эх эсвэл асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн паспортоор гарч болно.

210. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 38 дугаар зүйл Монгол Улсын хууль тогтоомжид тодорхой заагдсан. Цэргийн алба хаах насны доод хэмжээг 18 насаар тогтоосон. 18 нас хүрээгүй хүн цэргийн алба хаахгүй. Монгол Улсад цэргийн алба хаах дундаж нас бол 18–19 нас юм.

### **Б. Хууль зөрчсөн хүүхэд**

#### **40 дүгээр зүйл**

211. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу 16–аас дээш насны хүүхэд эрүүгийн гэмт хэрэгт хариуцлага хүлээнэ. Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүүхдүүдэд хэд хэдэн хөнгөлөлтүүд байдаг. Эдгээр нь гэмт хэргийн шинж, хүүхдийн нас зэргээс хамаарна. Түүнчлэн насанд хүрээгүй хүүхдэд цаазаар авах ял оногдуулахгүй байхаар заасан. Гэмт хэрэг үйлдсэн хүүхдэд чиглэсэн хууль зүйн арга хэмжээ нь хүүхдийг сургах, үйлдсэн гэмт хэргээ ухамсарлахад чиглэгддэг.

212. Сүүлийн жилүүдэд хууль зөрчсөн хүүхдийн тоо ихсэж байна. Энэ нь орон гэргүй хүүхдийн тоо ихсэж байгаа болон амьжиргааны түвшин буурч байгаатай холбоотой. Жишээ нь 1992 онд 885 хүүхэд гэмт хэрэгт холбогдсон бол 1993 онд 1247 хүүхэд гэмт хэрэгт холбогдсон байна.

## Эрх чөлөө нь хязгаарлагдсан хүүхдүүд

### 37 дугаар зүйл

213. Хуульд заасны дагуу хорих ял оногдуулсан, баривчилсан болон цагдан хорьсон тохиолдолд хүүхдийн эрх чөлөө хязгаарлагдахаар заасан. Эдгээр арга хэмжээг зөвхөн хуульд заасны дагуу авах бөгөөд түүний эцэг, эхэд нь мэдэгдсэний үндсэн дээр эцсийн арга хэмжээ болгож аль болох богино хугацаанд авч хэрэгжүүлдэг.

214. Өнөөдөр Монгол Улсад хүүхдийн хорих анги нэг байна. Одоогийн байдлаар 84 хүүхэд хүмүүжиж байна. Эдгээр 84 хүүхдийн 11 нь хүн амины гэмт хэрэг, 17 нь хүчингийн гэмт хэрэг, 50 нь өмчийн эсрэг гэмт хэрэг, 1 нь нийгмийн хэв журмын эсрэг гэмт хэрэг, 4 нь шүүхийн эсрэг гэмт хэрэгт бүртгэгдсэн байна. Эдгээр 84 хүүхдийн 4 нь сэхээтний, 60 ажилчны, 20 нь малчин өрхийн хүүхдүүд байна. Боловсролын түвшингийн хувьд 44 нь дунд боловсролтой, 38 нь бага боловсролтой, 2 нь боловсролгүй байна.

215. Хорих байгууллагын журамд зааснаар хүүхдүүд эцэг, эхтэйгээ уулзах боломжтой бөгөөд тодорхой хязгаарлалт байхгүй байна.

216. 1993 онд хүүхдийн хорих байгууллага Улаанбаатар хотын ойролцоо нүүж ирж улмаар хүүхдүүд сургалтад хамрагдах, мэдээлэл хүлээн авах болон гэр бүлтэйгээ харилцаатай байх боломжтой болсон. Эдгээр ялагдсан хүүхдүүдийн дунд явуулах үйл ажиллагааны хөтөлбөрийг 1993 онд шинэчилсэн. Одоогийн байдлаар эдгээр хүүхдүүдээс эрх нь зөрчигдсөн талаар ямарваа нэгэн гомдол гараагүй байна. Энэ нь магадгүй тэдгээрийн эрхийн талаарх мэдлэг хомс байдагтай холбоотой юм.

217. Эдгээр хүүхдүүдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах нь дараах хэд хэдэн хүчин зүйлээс хамаарч бэрхшээлтэй болж байна.

- а. Эдгээр хүүхдүүдтэй ажиллах мэргэжлийн боловсон хүчин байхгүй.
- б. Эдгээр хүүхдүүдийг нас, бусад шинж чанараас хамаарч тусгаарладаггүй. Өөрөөр хэлбэл тэд нэг дор амьдардаг. Энэ нь хүүхдийн ёс суртахуунд сөргөөр нөлөөлдөг.
- в. Эдгээр хүүхдүүдэд чиглэсэн хөтөлбөрийг боловсруулахдаа шинжлэх ухааны үүднээс ханддаггүй.
- г. Хорих ангийн санхүүжилтийн бэрхшээл

218. Дараах ажлуудыг хийх шаардлагатай байна.

- а. Эдгээр хүүхдүүдтэй ажиллах боловсон хүчнийг бэлтгэх;
- б. Хүмүүнлэг орчныг бий болгох;
- в. Эдгээр хүүхдүүдийн боловсролын хөтөлбөрийг хянан үзэх;
- г. Насанд хүрээгүй хүмүүсийн гэмт хэргийн талаар мэргэшсэн хуульчдыг бэлтгэх;

## В. Мөлжлөгт өртсөн хүүхдүүд

### 32 дугаар зүйл

Хүүхдийн эдийн засгийн мөлжлөг 32 дугаар зүйл

219. Хүүхдүүд Монгол Улсын Үндсэн хуулиар хөдөлмөр эрхлэлт, ажлын таатай нөхцөл, цалин хөлсөөр хангагдах зэргээр хамгаалагдсан. Үндсэн хуулийн энэхүү заалт нь бусад хууль тогтоомжид хангалттай тусгагдсан. Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар

хөдөлмөр эрхлэх насны доод хэмжээ 16 бөгөөд 14–15 насны хүүхдийг эцэг, эхийн зөвшөөрөлтэйгөөр ажилд авахаар заасан. Хуулийг зөрчсөн хүүхдийн хөдөлмөр буюу хүүхдийн хэвийн өсөлт хөгжилд сөргөөр нөлөөлөх ажлыг хатуу хориглосон.

220. 18 насанд хүрээгүй хүүхдийн эрхэлж болохгүй ажлын жагсаалтыг Засгийн газар гаргасан.

221. Хуульд 14–15 насны хүүхдийн 7 хоногт ажиллах цагийг 30 цагаар тогтоосон.

222. Хуулиар хүүхдийг мөлжиж ашиглахыг хориглосон. Гэвч сүүлийн жилүүдэд хүүхдийг бага цалингаар эсвэл цалин хөлс олгохгүй байх хэлбэрээр хүүхдийн хөдөлмөрийг мөлжиж буй тохиолдлууд ихсэж байна. Нөгөө талаар гэр бүлийн ядуурлын нөхцөл байдлаас хамаарч хүүхэд ямар ч ажлыг, ямар ч хөлсөөр хийхийг хүлээн зөвшөөрч байна.

223. 8 болон 10 дугаар анги төгсөгчдийн ихэнх нь ажилгүйчүүдийн эгнээнд орж байна. Гэвч Засгийн газар эхний ээлжинд эдгээр төгсөгчдөд ажлын байр бий болгох арга хэмжээ авч байна. 1992 оноос хойш хүүхдийн үндэсний төв товчоо байгуулах замаар эдгээр ажилгүй хүүхдүүдэд дэмжлэг үзүүлж байна. Өнөөдрийн байдлаар жил бүр 8 болон 10 дугаар ангийг 50 000 хүүхэд төгсөж байна. Эдгээрийн тал хувь нь ажилгүй болон гудамжны хүүхэд болж байна. Тэдгээрт ирээдүйн амьдралын баталгаа байхгүй байна.

### **Бэлгийн мөлжлөг ба хүчирхийлэл**

#### **34 дүгээр зүйл**

224. Монгол Улсын Эрүүгийн хуулиар хүүхдийг биеэ үнэлэхийг өдөөх, тулган шаардахыг хатуу хориглосон. Энэхүү заалтыг зөрчвөл 5 жил хорих ял болон эсвэл 50000–150000 төгрөгөөр торгоно. 1990 он гарснаас хойш Монгол Улсад биеэ үнэлэх явдал ихсэж байна. 1994 оны 6 дугаар сарын байдлаар цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн 67 биеэ үнэлэгчид байв. Эдгээр охид голчлон гэр бүл салсан эсвэл ядуу гэр бүлд хойд эцэг, эхтэй амьдардаг байна.

225. Учирч буй бэрхшээлүүд:

- а. Монгол Улс садар самуун болон бэлгийн асуудлыг сурталчлах, ухуулахын хувьд хаалттай улс байсан. Нийгмийн амьдралд гарч буй гэнэтийн өөрчлөлттэй холбоотойгоор эдгээр асуудлууд аливаа хязгаарлалтгүйгээр нээлттэй болсон. Энэ нь ийм төрлийн бизнест хүүхдүүдийг татагдахад нөлөөлсөн.
- б. Өмнө нь хүүхдүүдэд нөхөн үржихүйн талаар хөтөлбөр байсан.
- в. Ядуу өрхийн тоо ихсэж байгаатай холбоотойгоор хүүхдүүд нь амь зогоохын тулд бэлгийн мөлжлөгт өртөж байна.
- г. Эдгээр тохиолдлуудыг шийдвэрлэх нэгдсэн бодлого Засгийн газарт байхгүй байна.

226. Хэрэгжүүлэх ажлууд:

- а. Хүүхдийг эдгээр нийгмийн сөрөг үзэгдлээс хамгаалах;
- б. Сургалтын хөтөлбөрт хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах болон насанд хүрэгчдийн амьдралд бэлтгэх талаар тусгай сэдэв оруулах;
- в. Бэлгийн мөлжлөг болон хүчирхийллээс хүүхдийг хамгаалах нэгдсэн бодлого боловсруулах;

- г. Хүүхдийг нөхөн сэргээх болон хэвийн амьдралд эргэж ороход нь туслах арга хэмжээ зохион байгуулах;

### **IX хэсэг. Дүгнэлт**

227. Монгол Улс Хүүхдийн эрхийн тухай конвенцид нэгдэн орсноос хойшхи сүүлийн 4 жилд Монгол Улсад улс төр, эдийн засгийн гүнзгий өөрчлөлт явагдсан. Эдгээр өөрчлөлт шинэчлэлтийн зорилго нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, улс төрийн ардчиллыг хөгжүүлэх, эдийн засгийн харилцааг шинэчлэх, өмчийн бүх хэлбэрийг нэвтрүүлэх болон нээлттэй гадаад бодлого явуулах явдал юм. Эдгээр өөрчлөлтүүдийг 1992 оны шинэ Үндсэн хуулиар баталгаажуулсан. Одоогийн байдлаар Монгол Улс хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм байгуулах суурийг тавьж, Монгол Улсын ард түмэн ирээдүйдээ итгэх итгэлтэй болсон.

228. 1961 онд Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагад нэгдэн орсноос хойш манай улс НҮБ-ын хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаанд идэвхтэй оролцож ирсэн. Монгол Улс хүний эрхийн 20 гаруй конвенцид нэгдэн орсон.

229. Шинэ Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3-т “Монгол Улсын нэгдэн орж буй олон улсын гэрээ нь нэгдэн орсон буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасан. Энэхүү заалтын дагуу Хүүхдийн эрхийн тухай конвенц нь Монголын Улсад хуулийн нэгэн адил үйлчилнэ. Түүнчлэн конвенцийн гол зарчмууд эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөрийн талаарх Монгол Улсын хууль тогтоомжид тусгагдсан. 1992 оноос хойш хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжуудыг шинэ Үндсэн хуульд нийцүүлж өөрчлөн шинэчлэх ажлууд хийгдэж байна. Нийгэм, эдийн засгийн болон улс төрийн харилцааны өөрчлөлт амьдралын бүх салбарт явагдаж байна.

230. Өнөөдөр Монгол Улс шилжилтийн үед байгаа бусад улс орнуудын нэгэн адил бэрхшээлүүдтэй тулгарч байна. Хамгийн хүнд бэрхшээл бол эдийн засгийн хямрал. Эдийн засгийн хямрал, бэрхшээл нь нийгмийн амьдралд сөрөг нөлөө үзүүлж байна. Засгийн газар боловсрол, эрүүл мэнд болон нийгмийн салбарын хөгжлийн түвшинг хэвээр хадгалах, тогтоох бодлого баримталж байна. Гэвч эдгээр зорилгыг хэрэгжүүлэхэд санхүүгийн бэрхшээлтэй тулгарч байна. Нийгмийн эмзэг бүлэг, хүүхэд, ахмадууд энэхүү хүнд нөхцлийн хохирогч нь болж байна. Ажилгүйдлийн түвшин ихсэж, улмаар өнөөдрийн томоохон асуудлын нэг болоод байна. Монгол Улсын Засгийн газар 1994 оны 5 дугаар сард Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг боловсруулсан.

231. Сургууль завсардалт, ялангуяа хөдөө орон нутагт ихсэж, хүүхдийн эндэгдэл болон өвчлөлт, хүүхдийн тэжээлийн дутагдал зэрэг нь Засгийн газрын анхаарал татаж буй асуудлууд болоод байна.

232. Санхүүгийн бэрхшээлээс хамаарч хүүхэд асран халамжлах үйлчилгээ буурч байна. Өөрөөр хэлбэл эдийн засгийн хямралаас хамаарч сүүлийн дөрвөн жилд Монгол Улсын хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээнд ухралт, бууралт гарсан. Орон гэргүй тэнэмэл хүүхдийн асуудал нь хүн амын анхаарлыг татсан Монгол Улсад шинээр гарч буй асуудал болоод байна.

233. Шинээр бий болж буй нөхцөл байдлын үр дүнд, үндэсний болон уламжлалт үнэт зүйлс дээр тулгуурлан хүүхдэд чиглэсэн цоо шинэ хандлага, бодлогыг боловсруулах шаардлагатай байна. Түүнчлэн асуудлыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэхийн зэрэгцээ улс орны ирээдүй болсон үр хүүхдүүд, тэдгээрийн хөгжлийг хангах, эрхийг хамгаалах асуудалд Засгийн газрын анхаарлыг хандуулах зайлшгүй шаардлага бий болоод байна.

234. Үүнтэй холбоотойгоор Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулсан бөгөөд Улсын Их Хуралд өргөн барих гэж байна. Парламент энэ оны хаврын чуулганаараа хуулийн төслийг авч хэлэлцэнэ. Энэ хуулиар хүүхдийн эрхийг зөрчсөн, тэдгээрийн эрх ашгийг хөндсөн тохиолдолд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг тодорхойлж хуульчилна. Түүнчлэн хуулиар засаг төр, аж ахуйн нэгж, төр, төрийн бус байгууллагууд, гэр бүлийн үүрэг хариуцлагыг тодорхойлж, хүүхдийн хөгжлийг хангах шинэ орчинг бүрдүүлнэ гэж үзэж байна.

235. Засгийн газар Хүүхдийг хөгжүүлэх талаар 2000 он хүртэл баримтлах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийг баталсан бөгөөд түүнийг хэрэгжүүлэх ажил хийгдэж байна. Хөтөлбөр ирээдүйн 10 жилд хүүхэд, эмэгтэйчүүдийн ашиг сонирхлыг дээд зэргээр хангах талаар дэвшүүлсэн зорилгыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа, арга замыг тодорхойлсон. Хөтөлбөрийн эцсийн зорилго бол хүүхдийн эрхийг хангах явдал юм. Манай улсын Засгийн газар үүнийг хэрэгжүүлэхийн төлөө ажиллаж байна.

236. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө:

1. Улс төрийн хүсэл зориг, оролцоог идэвхжүүлэх. Дээд түвшний удирдлагуудын үйл ажиллагааг идэвхжүүлэн, дэмжих. Удирдагчид хүүхдийн эрх ашгийн төлөө ажиллах нь зөв бодлого бөгөөд энэ нь эдийн засагт ашигтай гэдгийг сайтар ухамсарладаг.
2. Нийгэм, эдийн засгийн болон үндэсний хөгжлийн бодлоготой нягт уялдуулан Хүүхдийн эрхийн тухай конвенц болон Үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
3. Үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үл төвлөрлийг дэмжих;
4. Нийгмийн эх үүсвэр болон олон нийтийн оролцоог дайчлан ашиглах;
5. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах болон мэдээллийн тогтолцоог бэхжүүлэх;
6. Хөтөлбөрийн амжилттай хэрэгжилтийг хангах үүднээс хоёр болон олон талын хамтын ажиллагааг хөгжүүлэх;
7. Дотоодын эх үүсвэрийг нэмэгдүүлэх бүхий л боломжийг судлах, гадаад болон дотоод санхүүгийн эх үүсвэрийн зардлыг нөхөн сэргээх талаар судлах. Эдийн засгийн харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх;
8. Хүүхдийн эрхийг сурталчлах, хамгаалахад хэвлэл мэдээлэл, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх. Холбогдох материал, гарын авлагыг боловсруулж гаргах;

237. Эмэгтэйчүүд, залуучууд, болон бусад олон нийтийн байгууллагууд конвенц болон үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийн заалтуудыг хэрэгжүүлэх ажилд оролцоно. Хүүхдийн эрхийн үндэсний төв гол үүргийг хэрэгжүүлнэ. Орон нутгийн засаг захиргаа, олон нийтийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдийн дэмжлэг дээр үндэслэн хүнд нөхцөл дэх хүүхдүүдэд бүх талын дэмжлэг үзүүлнэ.

## 6.2 ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ЭЭЛЖИТ ХОЁР ДАХЬ ИЛТГЭЛ (2003 ОН)

### Хүүхдийн эрхийн тухай НҮБ–ын конвенцийн хэрэгжилтийн тухай Үндэсний илтгэлийн агуулгын танилцуулга

Монгол Улс 1990 онд НҮБ–ын Хүүхдийн эрхийн конвенцид нэгдэн орсноос хойш уг конвенцийн хэрэгжилтийн тухай хоёр дахь удаагийн илтгэлийг НҮБ–ын Хүүхдийн эрхийн хороонд явуулахаар бэлтгэж байна.

Энэ илтгэл нь 1995–2000 оны хугацааг хамарч байгаа бөгөөд Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 44 дүгээр зүйлийн дагуу оролцогч орнуудын тогтмол гаргах тайлангийн агуулга, бүтцийн тухай Хорооны ерөнхий журам болон 1995 онд илгээсэн Монгол Улсын анхны илтгэлийг хэлэлцэн энэхүү Хорооноос ирүүлсэн зөвлөмж шаардлагыг үндэслэсэн болно.

Эл зөвлөмжийг үндэслэн холбогдох яам, төрийн ба төрийн бус байгууллагуудын боловсруулсан илтгэлийг 2001 оны 5 сард “Хүүхдийн аж байдал–НҮБ–ын Хүүхдийн эрхийн тухай конвенц” Үндэсний бага хурлаар хэлэлцүүлэн зөвшилцсөн болно.

Тайлан илтгэлийн ерөнхий бүтэц, агуулга:

1. Ерөнхий танилцуулга (44 дүгээр зүйл)
2. Конвенцийг хэрэгжүүлэхээр авсан ерөнхий арга хэмжээ (42.44 дүгээр зүйлүүд)
3. Хүүхдийн иргэний эрх ба эрх чөлөө (4. 7.8.13–17.37.42.44 дүгээр зүйлүүд)
4. Гэр бүлийн орчин, түүнийг орлох халамж үйлчилгээ (1–2.4.5.9–11.18–21.25.27.39 дүгээр зүйлүүд)
5. Хүүхдийн эрүүл мэнд (1–3.6.18.23–24.26–27 дугаар зүйлүүд)
6. Хүүхдийг тусгайлан хамгаалах арга хэмжээ (22.32–37.38–40 дүгээр зүйлүүд)
7. Хүүхдийн боловсрол хөгжил, оролцоо (28–32 дүгээр зүйлүүд)
8. Өмнөх илтгэлийн зөвлөмжийг хэрэгжүүлсэн тухай дүгнэлт
9. Илтгэлийн хавсралтууд

### I хэсэг

#### Ерөнхий танилцуулга

Монгол Улсын 1992 оны шинэ Үндсэн хуулиар хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалын эрх мэдлийг тусгаарлаж иргэдийн үг хэлэх, шашин шүтэх, эд хөрөнгө өмчлөх, бизнесийн хувийн үйл ажиллагаа явуулах эрхийг баталгаажуулан Ерөнхийлөгч, Улсын Их Хурлыг ард түмэн шууд сонгох эрхтэй болсон юм.

Улс төрийн ардчилсан өөрчлөлт түргэн бөгөөд нааштай үр дүнд хүргэж УИХ–ын 1992 оны сонгуульд Монгол Ардын Хувьсгал Нам, 1996 оны сонгуульд ардчилсан намуудын эвсэл, 2000 оны сонгуульд МАХН ялснаар засгийн эрх мэдэл улс төрийн нэг хүчнээс нөгөөд ардчиллын дагуу шилжиж байна. Өргөн уудам нутаг дэвсгэрт хүн ам сийрэг суурьшдаг ч эдгээр сонгуулиудад сонгогчдын 90–ээс дээш хувь оролцсон нь ардчиллыг

дэмжих иргэдийн урам зоригийн илрэл болсон юм.

УИХ-ын 2000 оны тогтоолоор баталсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт “Төрийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх, ард түмэндээ үр нөлөөтэй шуурхай үйлчилж, тэдний үндсэн хэрэгцээг хангах, шударга ёсыг хэвшүүлэх сайн засаглалыг бүрдүүлэх” зорилтыг тодорхойлсон юм.

Монгол Улс засаг захиргааны хувьд 21 аймаг, нийслэлд хуваагдана. Улаанбаатар хотод хүн амын 51 хувь нь аж төрдөг, 9 дүүрэгтэй юм. Аймгууд дунджаар 40–100 мян. хүн амтай бөгөөд засаг захиргааны үндсэн нэгж сум, сум нь багт хуваагддаг. Одоо нийт 324 сум, 1590 баг ажиллаж байна. Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогоор 2373.5 мянган хүн ам 541.1 мянган өрхөд тоологдсоноос 49,6 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Хүн амын 35,8 хувийг 15 хүртэлх насны хүүхэд, 60.7 хувийг 15–64 насныхан, 3.5 хувийг 65 ба түүнээс дээш насны хүн тус тус эзэлж байна. Хүн амын жилийн дундаж өсөлт 1969–1979 онд 2.9 хувь, 1979–1989 онд 2.5 хувь, байснаа 1989–2000 онд 1.4 хувь болсон байна. Гэсэн хэдий ч нийт хүн амын 45 хувийг 0–18 насны хүүхэд эзэлж, Монгол Улс залуу хүн амтай орны тоонд багтаж байна.

Бүх нийтэд бүрэн бус дунд боловсрол олгох, насанд хүрэгчдийг бичиг үсэгтэй болгох зорилтыг хэрэгжүүлэх боловсролын нэгдсэн тогтолцоог бүрдүүлснээр хүн амын 97.8 хувь (эрэгтэйчүүдийн 98 хувь, эмэгтэйчүүдийн 97.5 хувь) нь бичиг үсэгтэн болж, жил тутам 50000 хүүхэд суурь ба бүрэн дунд боловсрол эзэмшиж байна.

Хүн амын 2000 оны тооллогоор 15 ба түүнээс дээш насны хүн амын 51 хувь ажил эрхэлж, ажил хайж байгаа ажилгүйчүүд ажиллах хүчний 17.5 хувийг эзэлж байна. Ажил эрхлэлтийн түвшин 1995 онд 64.7 хувь байснаа 2000 онд 60,0 хувь болж буурсан байна.

Мал хувийн өмчид шилжсэн, мал экспортлох ажил багассан, цаг агаарын тааламжтай нөхцөл зэргээс хамаарч малын тоо 1999 онд 1995 оныхоос даруй 39.2 хувиар өссөн байсан юм. Гэвч өнгөрсөн 1999–2000 онд 15 аймгийн 158 сум зудад нэрвэгдсэнээс 3,5сая мал хорогдсон нь хөдөөгийн хүн амын амьжиргаанд хүнд цохилт болсон юм. Малын тоо толгойн өсөлт 1995– 2000 онд дараах байдалтай байлаа. Үүнд:

**Малын тоо  
(мян. толгойгоор)**

Малын төрөл	1995	1996	1997	1998	1999	2000
Тэмээ	367.5	357.9	355.4	356.5	355.6	322.9
Адуу	2648,4	2770,5	2893,2	3059,1	3163,5	2660,7
Үхэр	3317,1	3476,3	3612,8	3725,8	3824,7	3097,6
Хонь	13718,6	13560,6	14165,6	14694,2	15191,3	13876,4
Ямаа	8520,7	9134,8	10265,3	11061,9	11033,9	10269,8
Бүгд	28572,3	29300,1	31292,3	32897,5	33569,0	30227,4
Өсөлтийн хувь	6,6	2,5	6,8	5,1	2,0	-10,0

Монгол орны өнгөрсөн 10 жилийг эдийн засгийн талаас дүгнэхэд шилжилтийн үеийн уналт, сэргэлт хосолсон он жилүүд байв. Манай орны макро эдийн засгийн үзүүлэлтүүд 1995 оноос тодорхой хэмжээгээр сайжирсан хэдий ч 1990 оноос өмнөх түвшинд хүрч чадаагүй байна. Сүүлийн 3 жилийн дараалсан ган, зудын байдал мал аж ахуйн үйлдвэрлэлд томоохон хохирол учруулсан байна. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн уналтаас улбаатай ДНБ-ний өсөлт 2000 онд дөнгөж 1,1 хувьтай гарсан юм. Монгол Улсын макро эдийн засгийн 1996–2000 оны зарим үндсэн үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:

**Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд  
(ДНБ 1995 оны жишсэн үнээр)**

	1996	1997	1998	1999	2000
ДНБ-ний өсөлт (хувиар)	2.4	4	3.5	3.2	1.1
Аж үйлдвэрийн салбарын өсөлт (хувиар)	-3.6	-3.3	4.2	1.1	2.4
ХАА-н салбарын өсөлт (хувиар)	4.4	4.3	6.4	4.2	-14.3
Инфляцийн түвшин (хувиар)	44.6	20.5	6	10	8.1
Гадаад худалдааны тэнцэл (сая.төг)	-26.6	-16.8	-158.1	-154.5	-148.4
Төгрөгийн ханш (жилийн эцэст 1 ам.доллар)	693.5	813.2	902	1072	1097
Ажилгүйдлийн түвшин (бүртгэлтэй ажилгүйчүүдээр хувь)	6.7	7.7	5.9	4.7	4.6
ДНБ-д хөрөнгө оруулалтын эзлэх хувь	20.6	21.6	25.4	27.9	26.5
ДНБ-д төсвийн орлогын эзлэх хувь	25.2	26.7	29.4	28.8	33.5
ДНБ-д төсвийн зарлагын эзлэх хувь	32.7	34.5	41.9	39.4	39.5

Улс орны эдийн засаг, санхүүгийн байдал өнгөрсөн жилүүдэд хүнд байсан хэдий ч Монгол Улсын төр засаг хүүхдийн сайн сайхны төлөө чамгүй чармайлт тавьж, багагүй амжилт олсон он жилүүд байлаа.

Монгол Улс НҮБ-ын гишүүн болсон үеэс хойшхи хугацаанд хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой 20 гаруй конвенцид нэгдэн орсны нэг нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц юм. Энэхүү конвенцид манай улс 1990 онд нэгдэн орсноос хойш түүнийг хүүхдийн эрх, ашиг сонирхол, эрэлт хэрэгцээг хангахад баримтлах шинэ үзэл санаа, шинэ хэм хэмжээ гэж үзэж хэрэгжүүлэхийг эрмэлзэж байна. Хүний эрхийг хамгаалах алхмын нэг нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль” баталсан явдал юм. Хуулийн дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссыг УИХ-аас байгуулж 2001 оноос ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газар хүүхдийн сайн сайхны төлөө үндэсний дотоод нөөц бололцоог дайчлах замаар 2020-ын санаачлагыг хэрэгжүүлэх бодлого барьж байна. Эдүгээ манай оронд хүүхдийн эрх ашиг, эрүүл мэндийг хамгаалах, боловсрол олгох, авьяас чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн 20 шахам төрөлжсөн хөтөлбөрийн хүрээнд олон тооны төслийг хэрэгжүүлж байна.



Манай улс хүүхдийн нийгмийн суурь үйлчилгээнд зориулан зарцуулах хөрөнгийн хэмжээг жилээс жилд нэмэгдүүлэх чиглэлийг баримталж ирлээ. Хүүхэд, залуусын боловсролын төлөө улсын төсвийн жилийн орлогын 20-иос доошгүй хувийг зарцуулж байхаар хуульчилсан явдал маш том ололт болсон юм.

Сүүлийн 6 жилийн байдлаар улсын төсвийн зарлагын 44.4–52.3 хувьтай буюу ДНБ-ний 11.3–21.5 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг нийгмийн суурь үйлчилгээний тухайлбал боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, соёл, амралтын арга хэмжээний зардалд зарцуулсан байна.

Хүүхдийн эрхийг хамгаалах үйл ажиллагаанд нөөц хүчийг гурван чиглэлээр дайчлан зохион байгуулж байна.

### **Нэг. Улсын төвлөрсөн ба орон нутгийн төсвийн эх үүсвэрээс:**

#### **Хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр**

- Арван найман нас хүртэлх хүүхдийн эрүүл мэндийн даатгалын хураамж
- Хүүхэд, жирэмсэн эхчүүдэд үнэ төлбөргүй эмнэлгийн тусламж үзүүлэх
- Хүүхдийн дархлаажуулалтын вакцины зарим хэсгийн зардал
- Хүүхэд, өсвөр үеийг элдэв халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх
- Хүүхдийн хоол тэжээлийн дутагдлыг нөхөх
- Хүүхдийн эмнэлгийн үйлчилгээ

#### **Хүүхдийн боловсролын чиглэлээр**

- Сургуулийн өмнөх боловсрол олгох
- Хүүхдэд бага, суурь, бүрэн дунд боловсрол олгох
- Хүүхдэд боловсрол нөхөн олгох
- Хүүхдийн дотуур байрын хангамж, үйлчилгээ
- ЕБС-ийн хүүхдийн сурах бичиг зохиох, хэвлэх, түгээх
- Хүүхдэд мэргэжлийн баримжаа, анхан ба дунд шатны боловсрол олгох
- Албан бус боловсрол олгох
- Эмзэг бүлгийн олон хүүхэдтэй өрхийн хүүхдэд хичээлийн хэрэгсэл олгох

#### **Хүүхдийн хамгааллын чиглэлээр**

- Бүтэн өнчин хүүхдийг байнга асрамжлах үйлчилгээ
- Нялхсын асаргаа, сувилгаа
- Хүүхэд асарсны тэтгэмж
- Олон хүүхэдтэйн тэтгэмж
- Нярай хүүхдийн арчилгааны тэтгэмж
- Ихэр хүүхдийн тэтгэмж
- Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн өсгөсний тэтгэмж
- Гурав ба түүнээс дээш ихэр хүүхдийн асрамжийн үйлчилгээ
- Тахир дутуу хүүхдийн нэмэгдэл үйлчилгээ

- Хүүхдэд үзүүлэх яаралтай тусламж
- Төлбөрийн чадваргүй өрхийн насанд хүрээгүй хүүхдийн өмгөөллийн үйлчилгээ

**Хүүхдийн байгууллагын хөгжлийн чиглэлээр**

- Хүүхдийн төлөө байгууллагын үйл ажиллагаа
- Хүүхдийн зуслан, соёл хүмүүжлийн үйлчилгээ
- Хүүхдийн сургалт, уран бүтээлийн ажил
- Хүүхдийн эрхийн хамтын ажиллагаа

**Нийгмийн салбарын төсвийн зарлагын харьцуулалт  
(хувиар)**

	Төсвийн нийт зарлагад эзлэх хувь						ДНБ–д эзлэх хувь					
	1995	1996	1997	1998	1999	2000	1995	1996	1999	1998	1999	2000
Нийгмийн салбарын нийт зардал	49.1	44.4	45.5	46.2	48.4	52.3	13.3	11.3	16	19.4	19.1	21.5
Боловсролын үйл ажиллагаа	17	15.9	16.2	17.1	17.8	19.1	4.6	4	5.7	7.1	7	7.9
Эрүүл мэндийн үйл ажиллагаа	11.3	10.6	9.9	9.6	9.8	10.5	3.1	2.7	3.5	4	3.9	4.3
Нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	15.7	13,6	14.9	15.1	16.4	17.2	4.3	3.4	5.2	6.3	6.5	7.3
Орон сууц, нийтийн аж ахуйн үйл ажиллагаа	1.6	1.1	1.2	1.1	1.3	1.6	0.4	0.3	0.4	0.5	0.5	0.7
Амралт, биеийн тамир, соёл, урлагийн үйл ажиллагаа	3.5	3.2	3.2	3.3	3.1	3.3	1	0.8	1.1	1.4	1.2	1.4

*Эх сурвалж: СЭЗЯ, 2000*

**Хоёр.** Иргэд, аж ахуйн нэгж, төрийн ба төрийн бус байгууллагын зүгээс амьдралын гачигдалтай хүүхдэд зохих тусламж дэмжлэг үзүүлж байна. Мөн үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн мэдлийн хүүхдийн байгууллагын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх зэргээр сүүлийн жилүүдэд манай томоохон үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын зүгээс хүүхдийн үйл хэргийг дэмжих ажилд зарим ахиц гарч байна. Гэхдээ энэ хүрээнд нөөц бололцоог дайчлах ажлыг сайжруулах шаардлагатай байгаа бөгөөд энэ чиглэлийн статистикийн мэдээ, тайлан гаргах үндэсний сүлжээ хараахан бүрдээгүй байна.

**Гурав.** Олон улсын хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд ихээхэн өргөжиж байна. Эдийн засгийн уналтыг зогсоох, эдийн засгийн шинэчлэл ба бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэх, эдийн засгийг тогтворжуулах чиглэлээр ОУВС–тай 1991 оноос эхлэн тодорхой хөтөлбөрүүдийг үе шаттайгаар боловсруулан хэрэгжүүлж байна.

Өнгөрсөн 10 жилд буюу 1991–2000 оны хугацаанд хандивлагчид хөгжлийн албан ёсны тусламж (ХАЁТ)-ийн (зээл, тусламж, бүх хэлбэрийн төслийн, техникийн туслалцааны санхүүгийн) хүрээнд нийтдээ 2.6 тэрбум ам.долларыг Монгол Улсад олгохоор амласан тооцоо гарч байна. Нийт амласан ХАЁТ-ийн 72 хувь буюу 1.9 тэрбум ам.долларын зээл, тусламжийг бодитойгоор ашигласан байна. Нийт ашигласан ХАЁТ-ийн 52.4 (995,6 сая) хувийг буцалтгүй тусламж, 47,0 (904.4 сая) хувийг хөнгөлөлттэй зээл зээлж байна.

Шилжилтийн үеийн хүндрэл бэрхшээл, тулгамдсан яаралтай арга хэмжээг цаг алдалгүй түргэн шуурхай шийдвэрлэх, эдийн засгийн уналт, хямралыг гэтлэн давахад хандивлагчдаас олгож буй буцалтгүй тусламж онцгой үүрэг гүйцэтгэсээр байна.

Гадаадын зээл, тусламжийн ашиглалтын байдлыг тусламжийн төрлөөр нь үзэхэд эхний үед санхүүгийн буюу яаралтай тусламж давамгайлж байсан юм. Гадаадын зээл, тусламжийн бүтцэд яаралтай тусламжийн хувийн жинг бууруулах, хөгжлийн дунд болон урт хугацааны төслийн санхүүжилтийн эзлэх хувийн жинг өсгөх зарчмыг хэрэгжүүлэхэд Засгийн газар анхаарлаа төвлөрүүлж байна. Буцалтгүй тусламжийг хүний хүчин зүйлийг хөгжүүлэх, чадавхыг бүрдүүлэх, нийгмийн салбарын зорилтуудыг шийдвэрлэхэд чиглүүлэх болов. Энэ хандлагыг цаашид улам баталгаажуулах бодлогыг баримталж байна.

Манай улсын нийт ашигласан зээл, тусламжийн 37 хувийг дэд бүтцийн (эрчим хүч, зам, холбоо, хот, нийтийн аж ахуй) салбарт; 16,5 хувийг нийгмийн салбарын дэд бүтцэд (боловсрол, хүний нөөцийн хөгжил болон эрүүл мэнд); 10,8 хувийг аж үйлдвэрийн болон хөдөө аж ахуйн салбарт; 23, 0 хувийг санхүү, эдийн засгийн удирдлагын салбарт; 12,7 хувийг бусад салбарт тус тус зориулсан байна.

Нийт ашигласан буцалтгүй тусламжийн 60 хувийг Япон, 12 хувийг Герман, 9 хувийг АНУ, үлдсэн хэсгийг нь бусад орон, олон улсын байгууллагууд үзүүлсэн байна.

Эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг богино хугацаанд хийж, цаашдын хөгжлийн баттай суурийг тавих зорилгоор хандивлагчдаас өгч байгаа хөнгөлөлттэй зээлийг тэргүүн ээлжийн төсөл, арга хэмжээ, ялангуяа дэд бүтцийн болон нийгмийн салбарыг хөгжүүлэхэд зарцуулж байна. Ашигласан хөнгөлөлттэй зээлийн 40,0 хувийг Азийн хөгжлийн банк, 26,0 хувийг Япон, 18,0 хувийг Дэлхийн банк, 6 хувийг Герман, үлдсэн хэсгийг нь бусад улс олгосон байна. Эдгээр хандивлагчдын олгосон зээл ихээхэн хөнгөлөлттэй нөхцөлтэй бөгөөд төлөх хугацаа нь 30–40 жил, эхний 10 жилдээ үндсэн өрийн төлбөрөөс чөлөөлөгддөг, жилийн хүү нь 0,75–1,0 хувь байх юм.

Засгийн газар нийгмийн хүрээнд сүүлийн жилүүдэд олон тооны хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлж байгаа боловч ядуурал, ажилгүйдэл нийгмийн хурц асуудал хэвээр байна. Хүүхдийг хөгжүүлэх үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад багагүй амжилт олсон билээ. Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд 1996–2000 онд хүүхдэд хандсан нэмэлт ажлыг зохион байгуулав. Гэсэн хэдий ч хот, хөдөөд хүүхдийн ядуурал, амьдралын гачигдалтай байдал байсаар байна. Бүх хүүхэд төр, засгийн нийгмийн хамгааллыг тэгш хүртэж чадахгүй байна.

**Сургамж.**

- Хүүхдийн хэрэгцээ, эрх ашиг аливаа хөгжлийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл байх ёстойг өнгөрсөн жилүүдэд хуримтлуулсан туршлага, авсан сургамж нотолж байна.

Тухайлбал

- Аливаа өөрчлөлтийг хийхдээ хүүхдийн эрх ашигт тулгуурлаж байх
- Бодлого нь нэг хэсэг буюу бүлэг хүүхдэд нөлөөлж байгаа хүчин зүйлийг шийдвэрлэхэд чиглэгдэх
- Өргөн утгаар нь хүүхдийн эрхийг хангалттай хамгаалж, тэдний эрхийг зөрчих явдалтай үр дүнтэй тэмцэх
- Хүүхдийн гэр бүлд ялангуяа эрсдэл бүхий амьдралтай айл өрхөд дэмжлэг үзүүлэх явдлыг онцгой анхаарах
- Тогтвортой байдал, иргэдийн оролцоог дэмжсэн, үр дүн олох удирдлага, зохицуулалтын арга хэрэгслийг сонгож ажиллах зэрэг сургамж байна.

**II хэсэг**

**Конвенцийг хэрэгжүүлэхээр авсан ерөнхий арга хэмжээ**

Конвенцид нэгдсэнээс хойш түүний үзэл санаанд нийцүүлэн үндэсний хууль тогтоомжоо боловсронгуй болгохын зэрэгцээ “Төрөөс хүн амын талаар баримтлах бодлого”-ын баримт бичигтээ хүүхдийг хамгаалах, хөгжүүлэх, тэдний эсэн мэнд өсөж бойжих, сурч боловсрох, аж төрөх таатай нөхцөлийг бүрдүүлэх чиглэлийг тодорхойлсон байна. Үүнд:

**Эрүүл мэндийн чиглэлээр:** хүүхдийг хөхөөр хооллох, өсөлт хөгжилтийг хянах, амин дэмээр баялаг хоол тэжээлээр хангах, элдэв халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, 18 нас хүртэл нь эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төр хариуцах, хүүхдийг биемахбод, оюун санааны хувьд эрүүл байлгах, хүүхдийн сэтгэл зүйд нийцэхүйц таатай орчинг бүрдүүлэх

**Боловсрол, соёлын чиглэлээр:** Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын стандартыг олон улсын жишиг, үндэсний уламжлалыг харгалзан тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоо, агуулга, арга технологийг боловсронгуй болгох, хүүхдийн авьяасыг эрт хөгжүүлж, хөдөлмөрлөх дадал эзэмшүүлэх, оюуны хэрэгцээг хангахад чиглэсэн соёл урлагийн бүтээлийг урамшуулан дэмжих

**Эрх, оролцооны чиглэлээр:** Хүүхдийг эцэг, эхийн хайр асрамжид эсэн мэнд өсгөх, тэдний эрх ашгийг хамгаалах эрх зүйн үндсийг бүрдүүлж, хууль тогтоомжийн биелэлтэд төр, олон нийтийн хяналтыг хүчтэй болгох, хүүхдэд учруулж болзошгүй аливаа дарлал, мөлжлөг, доромжлол, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ авах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, харилцан биеэ хүндэтгэхэд сургах, Хүүхдийн олон нийтийн байгууллага, үүсгэл санаачилгын хөдөлгөөнийг дэмжин, хүүхдийн өөрийн удирдлагыг хөгжүүлэх, үндэстний цөөнхийн хүүхэд эх хэлээрээ суралцах, харилцах, соёл,

зан заншлаа өвлөх эрмэлзлэлийг хүндэтгэх

**Халамжийн асуудлаар:** Өнчин, тахир дутуу, эмгэг согогтой хүүхдийг төрийн ивээл халамжид байлгаж, хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдэд туслах, бага насны өнчин хүүхдийг үрчлүүлэх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох, ийм хүүхдийг асарч хүмүүжүүлж байгаа гэр бүл, иргэдэд туслах, хүүхдийн төлөө үйл ажиллагаанд улс үндэстний анхаарлыг төвлөрүүлэх, нийгмийн нөөц хүчийг татан оролцуулах, тэдний хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжих зэрэг болно.

“Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль”-ийг 1996 онд баталсан бөгөөд түүний үндсэн зорилт нь

- Хүүхдүүд онцгойгоор асрамжлуулах эрхийг хэрэгжүүлэх,
- Гэр бүлийг хамгаалан, хүүхэд өсөж хөгжих таатай орчныг бүрдүүлэх
- Хүүхэд нийгэмд бие даан аж төрөх, өв тэгш, энэрэнгүй үзэл санаагаар хүмүүжих
- Хүүхдийг тусгайлан хамгаалах эрх зүйн орчин бүрдүүлэх
- Хүнд хэцүү нөхцөлд амьдардаг хүүхдүүдийг нийгмийн хамгаалалтад авах
- Хүүхдийн амьдралын нөхцлийг сайжруулахад олон улсын хамтын ажиллагааг бодитой хэрэгжүүлэх зэрэгт чиглэж байна.

Хүний эрхийн хэм хэмжээ, зарчмыг үндэслэн Тэгш эрхийн талаар: Үндсэн хуулийн 14 дүгээр зүйл болон Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлд Хүүхэд бүрийн болон тэдний хууль ёсны асран хамгаалагчийн тэгш эрхтэйг заажээ. Конвенцийн үндсэн зарчмын нэг Хүүхдийн хувийн эрх, эрх чөлөөг: үндэсний хууль тогтоомжид өргөн цар хүрээтэй авч үзэн хүүхэд амьд мэнд, эрүүл саруул өсөж торних, төрмөгцөө бүртгэгдэх, нэр авах, иргэний харьяалалтай болох боломжийн хэрээр өөрийн эцэг, эхийг мэдэх, түүнчлэн тахир дутуу, оюуны хомсдолтой хүүхэд нэр төрөө хангахуйц нөхцөлд зохих ёсоор төгс төгөлдөр аж төрөх зэрэг эрхийг эдгээр хууль тогтоомжоор бэхжүүлэв.

- Гэр бүлийн хуулийн 98 дугаар зүйлд хүүхдийг төрснөөс хойш 30 хоногийн дотор бүртгэх, мөн хуулийн 39 дүгээр зүйлд хүүхэд овог нэртэй байх тухай, мөн Монгол Улсын харьяатын тухай хуулиар харьяат болох үндэслэл журмыг хуульчилжээ.
- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 7.1–д хүүхдийн гэр бүл, эцэг, эхээс нь хууль бусаар салгаж үл болно, мөн хуулийн 3–т хувийн байдлаа хамгаалуулах, мөн хуулийн 5. 3–т хүүхэд эцэг, эхээсээ буюу бусад хэн нэгнээс нь тусдаа амьдрах үед тэдэнтэй байнгын харилцаатай байх, эцэг, эх гэрлэлтээ цуцлуулсан, тусдаа амьдрах үед хэнтэй нь амьдрах саналаа илэрхийлэх эрхтэйг, мөн хуулийн 5–д хүүхэд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамт гадаадад цагаачлах, дүрвэх, байнга амьдрах, эх орондоо эргэн ирэх эрхтэй гэж заасан байна.
- Үндсэн хуулийн 16,13–т заасныг үндэслэн Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 1,13–т хүүхэд хувийн болон захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаалуулах эрхтэй бөгөөд эдгээр заалтын эрх зүйн баталгааны үндсийг Иргэний болон Эрүүгийн холбогдох хуулиар зохицуулж байна.

**Нийгэм, эдийн засгийн эрх, эрх чөлөөг:** Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлд онцгой ба хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдэд үзүүлэх нийгмийн халамж, тусламжийн эрх зүйн үндсийг тогтоож, бүтэн өнчин, тахир дутуу, нэн ядуу, хараа хяналтгүй, садар самуун, хүчирхийлэл, доромжлолын улмаас сэтгэл санааны болон бие махбодын хохирол хүлээсэн хүүхдийг хүнд нөхцөлд байгаа хүүхэд гэж үзэхийг;

- Үндсэн хуулийн 16-ийн 6-д заасан иргэд эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхийг үндэслэн Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 5-ын 4-д Хүүхэд төрөөс эмнэлгийн тусламж авна, тэгэхдээ Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд даатгуулсан эсэхээс үл хамааран эмнэлгийн зарим төрлийн тухайлбал эмчийн үзлэг болон өөрийнх нь хүсэлтээр хийх бүх төрлийн лабораторийн шинжилгээ, сүрьеэ, бруцеллөз, дархлалын өвчин, удмын эмгэг, хорт хавдар зэрэг эмчилгээг үнэ төлбөргүй үзүүлэхийг;
- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 5-ын 4-т хүүхэд төрөөс тэтгэвэр, тэтгэмж, асрамж, халамж авах эрхтэй бөгөөд түүний хэрэгжүүлэх баталгааг бусад хуулиар зохицуулсан байна. Жишээ нь:
  - а. Жирэмсний болон амаржсаны, хүүхэд асарсны, олон хүүхэдтэйн, нярай болон ихэр хүүхдийн арчилгааны, бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч өсгөсний тэтгэмжийг төрөөс олгохыг;
  - б. Хүүхэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй бөгөөд харин хүүхдийг хоол хүнс, орон байр, ахуйн хэрэгслээр санаатай гачигдуулах, эрүүл ахуйн шаардлагад нийцээгүй хоол хүнсээр хангах явдлыг хориглохыг;
  - в. Үндсэн хуулийн 16-гийн 7-д төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгохоор заасан бөгөөд энэ заалтыг иш үндэс болгон Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 6-гийн 1-д ерөнхий боловсролыг төлбөргүй эзэмших, төрөлх хэл, бичиг үсэг, ур чадвараа хөгжүүлэхэд нь хүүхдэд төр тусламж дэмжлэг үзүүлэхийг;
  - г. Хүүхдийн нас бие, эрүүл мэндэд нь үл нийцэх хөдөлмөр эрхлүүлэхийг хориглож, Хөдөлмөрийн тухай хуульд насанд хүрээгүй ажилтныг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт, ажил, амралтын цагийг нарийвчлан тодорхойлсон байдаг.

**Хүүхдийн улс төрийн эрхийн талаар:** Үндсэн хуулийн 16.13-т хэнд ч эрүү шүүлт тулгах, түүнтэй адилтгах арга хэмжээ авахыг хориглосон заалтыг үндэслэн Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 7.4-т хүүхдийг хууль бусаар хорьж цагдах, мөн зүйлийн 6-д хүүхдийг насанд хүрэгчидтэй хамт хорихыг хориглосон байна.

- Үндсэн хуулийн 16.16-д иргэн итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй гэж заасныг үндэслэн Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 6.5-д хүүхэд чөлөөтэй бодож сэтгэх, мэдээлэл хайх, мөн 8. 3-т хүүхэд өөрт нь зориулсан сургалт, эмчилгээ, асрамж сувилал, бусад үйлчилгээний талаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй байх эрх зүйн үндсийг тогтоосон болно.

Хүүхдийн эрх, эрх чөлөөг хязгаарлах үндэслэл, журмыг гагцхүү төрийн хуулиар

тогтоох бөгөөд хүүхдийн эрх, эрх чөлөө нь түүний хууль ёсны үүрэг, хариуцлагатай салшгүй холбоотой явдал манай эрх зүйн нэг гол зарчим юм. Үүний зэрэгцээ хүүхэд нийгэм, төр, эцэг, эхийнхээ өмнө зохих ёсны үүрэг хүлээх бөгөөд ийнхүү эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ бусдын эрх, эрх чөлөөг үгүйсгэсэн аливаа ажиллагаа явуулахгүй байж тэдгээрийг зөвшөөрөн хүндлэх, ёс суртахууны шударга шаардлагыг биелүүлэх, ардчилсан нийгэмд байдаг хэв журам, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосон зохих хязгаарлалтад л захирагдах учиртай.

Хүүхдийн эрхийн талаарх үзэл баримтлал нь төрийн бодлогоор тодорхойлогдон, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн болон түүнийг хэрэгжүүлэхэд оролцдог бусад байгууллагуудын үйл ажиллагаагаар хэрэгжиж байна.

Монгол Улсын Их Хурлаас 1998 оны 1 сард гаргасан Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрт, Эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэхдээ төрт ёсны дэвшилт уламжлал, эрх зүйн тогтолцооны арга хэлбэрийг харгалзан, дэлхийн улс орнуудын нийтлэг чиг хандлага, өөрийн орны өвөрмөц нөхцөл байдал, үндэсний ашиг сонирхолд нийцүүлэх зарчимд тулгуурлан хүний эрх, эрх чөлөө, түүний хууль зүйн баталгааг хангахыг чухалчилж байгааг тодорхойлжээ.

Хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн орчны шинэчлэл нь хүүхдийн эрхийн талаар гарсан олон улсын гэрээ, конвенц, тунхаглалын үзэл санааг хүлээн зөвшөөрч, түүнд нэгдэн орох, Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн агуулга, зарчимд нийцүүлсэн хүүхдийн эрхийг баталгаажуулсан үндэсний эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх, төрөөс хүүхдийн эрхийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгыг агуулж байна.

Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн агуулга, заалтуудыг Монгол Улсын 50 гаруй хуульд тусгасан байна. Тайлангийн хугацаанд Хүүхдийг хамгаалах, улс хооронд үрчлэх тухай, Гаагийн конвенцид 1998 онд, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай ОУХБ-ын 182 дугаар конвенцид 2000 онд тус тус нэгдэн орлоо.

Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх НҮБ-ын үндсэн зарчим (Эр-Риядын), Насанд хүрээгүй хүмүүсийг байцаан шийтгэх ажиллагаа явуулах НҮБ-ын (Бээжингийн) наад захын жишиг дүрэм, Ял эдэлж байгаа насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах тухай НҮБ-ын дүрмүүдийг хэрэгжүүлэхийг эрмэлзэж байгаа бөгөөд Хүүхдийн эрхийн тухай конвенцийн, Цэргийн мөргөлдөөнд хүүхдийг татан оруулахгүй байх тухай, Хүүхдийг худалдах, садар самуунд болон бэлгийн хэлбэрт ашиглахаас сэргийлэх тухай нэмэлт протоколуудад гарын үсэг зураад байна. Энэ арга хэмжээний үр дүнд хүүхдийн эрх баталгаажих, хүүхдэд ээлтэй хууль, эрх зүйн орчин алхам алхмаар бүрэлдэн тогтож, тэдгээрийг боловсронгуй болгох ажил эрчимтэй явагдаж байна.

Хүүхдийн эсэн мэнд өсөж бойжих нөхцлийг хангах, хамгаалах, хөгжүүлэх тухай дэлхий дахины тунхаглалын үзэл санаа, зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газар Хүүхдийг хөгжүүлэх талаар 2000 он хүртэл баримтлах үйл ажиллагааны Үндэсний хөтөлбөрийг өнгөрсөн 10 жилд НҮБ-ын Хүүхдийн сангийн тусламжтайгаар хэрэгжүүллээ. Хөтөлбөрт хүүхдийн эрүүл мэнд, хоол хүнс, боловсролын асуудал, бага насны тахир дутуу хүүхэд, хүнд нөхцөлд байгаа хүүхэд, эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулах болон усан хангамж, эрүүл ахуйн асуудлуудыг тэргүүлэх чиглэл болгон тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нарийвчлан тусгасан юм.

**Үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийн үндсэн зорилтын хэрэгжилтийн байдал**

	Тавьсан зорилт	Өмнөх түвшин	2000 оны зорилт	Одоо хүрсэн түвшин
1	Мянган амьд төрөлт дахь нялхсын эндэгдэл	62	49	31.2
	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	82	61	42.41
2	1000 амьд төрөлт дэх эхийн эндэгдэл	205	105	1582
3	0–4 насны хүүхдийн тураал, хоол тэжээлийн дутагдал (хувиар)	13	6,5	–
4	Төвлөрсөн усан хангамж болон худгаас ундны ус хэрэглэгч хүн амын хувь	60 (1988)	85	60.5
	Ариун цэврийн шаардлага хангасан гэрийн болон нийтийн бие засах газрын хангамж (хувиар)	40 (1988)	75	73.9
5	Суурь боловсрол эзэмшүүлэлтийн хувь	95 (1990)	98	75.6
6	Насанд хүрэгчдийн бичиг үсэг үл тайлагдалтын хувь	4 (1991)	2	1.5
7	Хүнд нөхцөлд байгаа хүүхдийн нийгмийн хамгааллын арга хэмжээг өргөтгөн гэр бүлд үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлэх	–	–	Нийт хүүхдийн 22% хүнд нөхцөлд амьдарч байна.

1. ЭМЯ–ны мэдээ, 2000 он. Энэ үзүүлэлт “Хүүхэд хөгжил 2000” судалгаанд 64, 87 байгаа юм.

2. Эрүүл мэндийн салбарын тойм, ЗГ, ДЭМБ, 1999

Энэ хөтөлбөрийн дунд хугацааны хэрэгжилтийн тайланг 1997 оны 5 дугаар сард Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж хөтөлбөрийн дунд хугацааны зорилтын хэрэгжилтэд дүгнэлт өгч, төгсгөлийн хугацааны зорилтын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай шийдвэр гаргаж байсан болно.

Үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд НҮБ–ын Хүүхдийн сан, ДЭМБ, НҮБ–ын Хүн амын сан зэрэг байгууллагын техникийн тусламж голлох үүрэг гүйцэтгэж, нялхсын болон хүүхдийн эндэгдлийг бууруулах, вакцинжуулалт, суурь боловсрол эзэмшүүлэх зэрэгт тодорхой амжилт гарсан байна. Мөн иргэдийн дунд хүүхдийн эрхийн боловсролын түвшинг дээшлүүлэх ажилд зохих туршлага хуримтлууллаа. Ялангуяа хүүхдийн сурч боловсрох, эрүүл мэндийг хамгаалах, сургуульд хамрагдалтыг нэмэгдүүлэх, хүүхдийг вакцинжуулах, хөхөөр хооллох, хүнд нөхцөлд байгаа хүүхдүүдэд халамж үйлчилгээ үзүүлэх, иодын дутагдлаас сэргийлэх зэрэг төсөл, хөтөлбөрүүд зохих үр дүнгээ өгснийг тэмдэглэж байна. Гэвч хөтөлбөрийн зарим



зорилтууд хангагдаагүй нь хэрэгжүүлэх арга хэлбэр, хөрөнгө төсөв зэргээс шалтгаалсан юм.

Засгийн газар НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран өнгөрсөн 10 жилийн туршлагад үндэслэн Хүүхдийг хөгжүүлэх талаар 2010 он хүртэл баримтлах хөтөлбөрийн стратегийг боловсруулж байна. Уг баримт бичигт өмнөх хөтөлбөрийн бүрэн хэрэгжээгүй зорилтуудад анхаарлаа хандуулахын зэрэгцээ хүрсэн амжилтаа бататган тогтворжуулахыг зорьж байна.

Хүүхдийн ялангуяа бага насны хүүхдийн хамгаалал, ундны цэвэр ус, эрүүл орчин, эхийн эндэгдэл, хүүхдийн хоол тэжээлийн дутагдал, насанд хүрээгүй хүмүүсийн эрхийг хамгаалах зэрэгт илүү анхаарч, хүчин чармайлт гаргах шаардлагатай байна.

Хүүхдүүд өлсөх, даарах, сургууль завсардах, хүчирхийлэлд өртөх, гэр орноосоо дайжих, хүнд хүчир хөдөлмөр эрхлэх явдал дорвитой буурахгүй байгаад сэтгэл зовниж байна. Иймд хүүхдийн эрхийг хамгаалах үйл ажиллагааг гэр бүлийн хүрээнд төвлөрүүлж, өрхийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлэх нийгмийн шаардлага тавигдаж байна.

Засгийн газар орон нутгийн засаг захиргааны хүүхдийн төлөө хүлээх үүрэг, хариуцлагыг өндөржүүлж, олон нийтийн идэвхтэй оролцоог ханган, нийгмийн түншлэлийг сайжруулснаар үйл ажиллагааныхаа тэргүүлэх чиглэлийн зорилтуудыг биелүүлнэ гэж үзэж байна. Хүнд нөхцөлд байгаа хүүхдийн хамгааллын асуудал нь эрүүл мэнд, хоол тэжээл, боловсрол, сэтгэл зүй, ёс суртахуун, эцэг, эхийн аж амьдрал зэрэг олон хүчин зүйлээс хамааралтай учир тулгамдсан асуудалд хүчээ нэгтгэж, үйл ажиллагаагаа уялдуулах нь хүүхдэд хүрэх үйлчилгээний үр дүнг дээшлүүлж чадна гэдэгт төрийн ба төрийн бус байгууллагууд, хандивлагч улс орон, байгууллагууд ч санал нэгдэж байна.

Хүүхдийн асуудлаар бодлого боловсруулж, хэрэгжилтийг хянах үүрэг бүхий Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, бодлогын хэрэгжилтийг хангах үүрэг бүхий Хүүхдийн төлөө Үндэсний хороо, хүүхдийн сайн сайхны төлөө нийгмийн нөөц хүчийг дайчлан зохион байгуулах, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо, хамтын ажиллагааг зохицуулах, зөвшилцөх үүрэг бүхий Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөл зэрэг нь үндэсний тогтолцоотой ажиллаж байна. Энэ бүтцийг Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулиар бий болгосон нь хүүхдийн төлөө төрийн бодлого, үйл ажиллагааг олон нийтийн үүсгэл санаачилгад тулгуурлан хэрэгжүүлэхэд түлхэц болж байна.

Тайлангийн хугацаанд хүүхдийн эрхийн салбарт гарсан амжилтууд нь хүүхдийн талаарх бодлого, ялангуяа олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааны түвшинд гарсан өөрчлөлттэй салшгүй холбоотой юм.

Хүүхдийн эрхийн тухай конвенцийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж байгаа НҮБ-ын Хүүхдийн Сан, Английн Хүүхдийг ивээх сан, Норвегийн Хүүхдийг ивээх сан, Дэлхийн зөн байгууллага болон хүмүүнлэгийн олон улсын байгууллагуудад талархаж байна.

Улс төрийн шинэчлэл, нийгмийн өөрчлөлт хийгээд эдийн засгийн шилжилтийн үед үүссэн ажилгүйдэл, ядуурлын улмаас хүн амын эмзэг хэсэг болох хүүхэд, хөгшдийн амьдрах нөхцөл, бололцоо нь улам хүндэрч байна. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн нийгмийн салбарт баримтлах үндсэн зорилт нь хүний хөгжлийг хангах

орчин бүрдүүлэх, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэх, нийгмийн үйлчилгээг хүртээмжтэй болгох, ажилгүйдэл ядуурлыг бууруулахад чиглэгдэж байгаа бөгөөд Засгийн газар төсвийнхөө 20 орчим хувийг хүүхдийн боловсрол, эрүүл мэнд болон нийгмийн хамгааллын арга хэмжээнд зориулдаг ч хувь хүн, эцэг, эх, гэр бүлийн зүгээс хүүхдийнхээ сайн сайхны төлөө тавих анхаарал халамж, идэвх санаачилга жигд бус байна.

Засгийн газар нь амьдралын хүнд нөхцөлд байгаа хүүхдийн өсөж бойжих, сурч боловсрох, хөгжих бололцоог хангахдаа нэн түрүүнд хүүхдийн хөгжлийг дэмжих байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, хүүхдийн байдлыг олон нийтийн зүгээс хянахыг чухалчилж байна.

Засгийн газар 1997 оныг Хүүхдийн, 1998 оныг Залуучуудын, 1999 оныг Ахмадын, 2000 оныг Хүүхдийн хөгжлийг дэмжих, 2001 оныг Тахир дутуу иргэдийг дэмжих жил хэмээн зарлаж олон нийтийн хүч анхаарлыг хандуулж ирлээ.

Энэ нь нийгмийн үйлчилгээний (эмнэлэг, нийгэм ахуйн үйлчилгээ, боловсрол) чанар, хүртээмжийг нэрлэсэн бүлгүүдэд чиглүүлэхэд дөхөмтэй алхам болсон юм. Гэвч хүүхдийн эрх ашгийг бүх нийтээр хамгаалахад тулгамдсан асуудал багагүй байна.

Хараа хяналтгүй хүүхдийг нийгмийн амьдралд төлөвшүүлэх тэр дундаа гэр бүлд ойртуулах ажлыг хэрэгжүүлэх эдийн засгийн болон нийгмийн таатай орчин хараахан бүрдээгүй байна.

- Холбогдох хууль тогтоомжуудад хүүхдээ хараа хяналтаас гаргасан буюу гэр орондоо хүмүүжүүлж чадаагүй эцэг, эхчүүдэд хариуцлага тооцох, торгууль ногдуулах тухай хуулийн заалт тэр бүр хэрэгжихгүй байна. Хүүхдийн аливаа асуудлыг гэр бүлтэй нь холбон шийдвэрлэх, гэр бүл, эцэг, эхийг дэмжих, урамшуулах арга хэрэгсэл үгүйлэгдэж байна.
- Гэр бүлийг дэмжихэд чиглэсэн “Гэр бүл” төвтэй нийгмийн ажлын талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд засаг захиргааны нэгжийн чадавх сул байна.
- Иргэний байгууллагуудын нөөц хүчийг дайчлах, хамтран ажиллах, энэ ажилд олон нийт, иргэдийн анхаарлыг чиглүүлэх стратеги цэгцрээгүй байна.
- Хүүхдийн оюуны хэрэгцээг хангахад зориулсан хүүхдийн мэдээллийн хэрэгслийн бие даасан суваг, хөтөлбөр үгүйлэгдэж байна. Хүүхдэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг дэмжих, тэдний төлөө зориулсан зээл, тусламж, төслийн хэрэгжилтийн биелэлтийг ил тод тайлагнах, хяналт тавих арга хэрэгсэл бүрдээгүй байна.

Төрийн бодлогод хүнд нөхцөлд байгаа хүүхдийн асуудал онцгой байр суурь эзэлж байна. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд зааснаар байгалийн гамшиг, гоц халдварт өвчин, нийтийг хамарсан гэнэтийн осол, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн хүүхдийг онцгой нөхцөлд байгаа хүүхэд гэж үздэг бөгөөд ийм нөхцөлд орсон хүүхдэд үзүүлэх яаралтай тусламжийн асуудлыг Засгийн газар тухай бүрд нь тусгайлан авч үзэж шийдвэрлэж байна. Харин бүтэн өнчин, тахир дутуу, нэн ядуу, хорих газар хүмүүжиж байгаа, эцэг, эхийн хараа хяналтаас хөндийрсөн, садар самуун, хүчирхийлэл, доромжлолд өртсөн хүүхдийг хүнд нөхцөлд байгаа хүүхэд хэмээн үзэж, тэдэнд нийгмийн халамжийн хууль тогтоомж, нийгмийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд халамж, үйлчилгээ үзүүлж байна.

Нийгмийн халамжийн сангийн тайлангаас үзвэл 2000 онд эхчүүдийн жирэмсний болон амаржсаны, хүүхэд асарсны, ихэр болон нярай хүүхдийн арчилгааны, бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч өсгөсний тэтгэмжид 81,7 мянган хүнийг хамруулан 5,3 тэрбум төгрөг зарцуулсан байна. Мөн дөрвөөс дээш хүүхэдтэй 20 гаруй мянган өрхөд 700 орчим сая төгрөгийн тэтгэмж олгожээ. Түүнчлэн нийгмийн халамжийн тэтгэврийн 40 гаруй хувь, асрамж үйлчилгээний зардлын 30 гаруй хувь, тахир дутуу иргэдийн хөнгөлөлт үйлчилгээний зардлын 20 орчим хувь нь хүүхдэд зориулагдаж байна. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу 16 хүртэл насны 109,6 мянган хүүхдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлд төрөөс 3946,7 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас давхардсан тоогоор 194,9 мянган хүүхдийн эмчилгээ, үйлчилгээний зардалд 4569,5 мянган төгрөг зарцуулсан байна. Өнчин хүүхдийн асрамжийн газарт одоогоор 500 орчим хүүхэд, нялхасын клиник сувилалд эцэг, эх нь орхисон “олдмол” нэртэй 100 гаруй хүүхдүүд асруулж байна.

Сос Киндердорф байгууллагатай өнчин хүүхдийн тосгон (140 ортой) байгуулахаар хамтын ажиллагааны гэрээ хийсэн бөгөөд 1сая ам.долларыг Сос Киндердорф байгууллага, гадна талын зам, холбоо, цахилгаан шугамын холболтын зардалд 27,7 сая төгрөгийг Засгийн газар санхүүжүүлээд байна.

Засгийн газар ОУХБ-тай Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөрийн хүрээнд хамтран ажиллах Ойлголцлын санамж бичигт 1999 онд гарын үсэг зурсан юм. Энэ хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр хүүхдийн хөдөлмөрийн талаар мэдээлэл цуглуулах, судалгаа хийх сургалт зохиох, хүүхдийн хөдөлмөрийг устгахад чиглэсэн төслүүдийг хэрэгжүүлэх зэрэг олон талт үйл ажиллагааг явуулж байна.

Ядуурлыг бууруулах болон сургуулийн өмнөх боловсролын Үндэсний хөтөлбөрийн хүрээнд сургуулийн өмнөх боловсролын чиглэлээр 1059.6 сая төгрөгийн өртөг бүхий 649 төслийг хэрэгжүүлсний дүнд сургуулийн өмнөх боловсролд хамрагдах түвшин 1995 оныхоос 13.3 хувиар ахиж 2000 онд 37.7 хувь болсон байна. Хөтөлбөр төслүүд нь сургуулийн өмнөх байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, нийгмийн эмзэг хэсэгт багтах бага насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсрол олгох сургалтад хамруулахад багагүй үр нөлөө үзүүлээ.

Хүүхдийн төлөө үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага 2001 оны байдлаар 70 гаруй байна. Нийгэм, хүүхдийн сайн сайхны төлөө үйл ажиллагаа явуулж байгаа иргэний 23 байгууллага 1999 оны 3 сард нэгдэн үйл ажиллагаагаа уялдуулах, хамтран ажиллаж Хүүхдийн эрхийн тухай конвенцийг хэрэгжүүлэхээр тохирч, “Үндэсний эвсэл” –ийг байгуулсан бөгөөд түүнд 50 шахам байгууллага нэгдэн ажиллаж байна.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц, хүүхдийн сайн сайхны төлөө үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагын чуулга уулзалтыг жил бүр зохион байгуулж өөрсдийн үйл ажиллагааг сурталчлан конвенцийг хэрэгжүүлэхэд төрийн бус байгууллагуудын оролцоо, төрийн байгууллагуудын хамтран ажиллах чиглэлийг тодорхойлж, зөвшилцөн ажилладаг боллоо. Үүнд:

**Хүүхдийн эсэн мэнд амьдрах талаар:** Гэр бүлд хүүхдийн эсэн мэнд амьдрах нөхцлийг дэмжин, эцэг, эхийн амьдрах, аж төрөх арга ухаан, сурган хүмүүжүүлэх үр чадварыг дээшлүүлэх, сургалт, сурталчилгааг өргөжүүлэх,

Гэр бүлийг ядуурлаас сэргийлэх, орлогыг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд төрийн бүх шатны байгууллагын оролцоог өргөжүүлэх,

Хүнсний аюулгүй байдлыг хангах, хүүхдэд зориулсан үзвэр, үйлчилгээний чанарыг сайжруулах, түүнд тавих олон нийтийн хяналтыг өндөржүүлэх зорилгоор “Хүүхэд эрхэм хэрэглэгч” олон нийтийн хөдөлгөөнийг өрнүүлэх,

Иргэний болон хүүхэд төрөлтийн бүртгэлийг сайжруулах арга замын талаар олон нийтийн санаа бодлыг төрийн холбогдох шатны байгууллагад уламжлах, энэ асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх,

Хүүхэд, залуучуудад эрүүл аж төрөх ёсны мэдлэг, дадал чадвар олгоход чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг сургууль, багш нартай хамтран зохион байгуулах,

Хүүхэд, залуучуудад зөвлөлгөө өгөх нийгэм, сэтгэл зүйн алба байгуулах, ийм төрлийн үйлчилгээг бий болгохыг дэмжих,

**Хүүхдийн хөгжих эрхийг хангах талаар:** Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийг үндэслэн төрийн тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гэрээгээр хариуцан гүйцэтгэх хэлбэр, хүрээг өргөжүүлэх,

Спортын болон урлагийн наадмыг төрийн байгууллагатай хамтран үндэсний хэмжээнд зохион байгуулах,

Сургууль завсардалтаас урьдчилан сэргийлэх, завсардсан хүүхдүүдэд боловсрол нөхөн олгох, цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдийг сургуульд бэлтгэхэд чиглэсэн үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлэхэд төрийн байгууллагатай хамтран ажиллах,

Хүүхдийн нас, бие, сэтгэхүйн онцлогт тохирсон мэдээ, мэдээллийг хөгжүүлэх, мэдээллийн эерэг орчин бүрдүүлэхэд туслалцаа үзүүлэх,

Хүүхдийн хөгжлийн талаарх судалгаа, шинжилгээний ажлыг төрийн байгууллагуудтай хамтран хийж гүйцэтгэх,

**Хүүхдийн хамгаалуулах эрхийг хэрэгжүүлэх талаар:** Хүүхдийн эрхийг хамгаалах үндэсний хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд төрийн бус байгууллагуудын идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх,

Төрийн ба төрийн бус байгууллагад ажиллах хүүхдийн эрхийн асуудлаар мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх ажилд дэмжлэг, туслалцаа үзүүлэх,

Гэр бүлд ялангуяа өсвөр насны охид, хөвгүүдийн хөгжлийг хөхиүлэн дэмжих,

Хүүхдэд эрх зүйн мэдлэг, чадвар, дадал олгоход илүүтэй анхаарах,

Хүүхдийн хөгжил, хамгааллын байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулсан мэдээллийн сүлжээг хөгжүүлэх,

**Хүүхдийн нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах талаар:** Хүүхдийн дуу хоолойг сонсох, тэдний үүсгэл санаачилга, санаа бодлыг төрийн байгууллагад болон олон нийтэд дамжуулж хүргэх ажлыг зохион байгуулах,

Хүүхдийн санал хүсэлт, хүсэл эрмэлзлэлийг дэмжиж, төрийн бус байгууллагууд өөрийн ивээлд хүүхдийн үүсгэл санаачлагын байгууллагыг дэмжин хөгжүүлэх, туслах чиглэл баримтлах,

Хүүхдийн үүсгэл санаачилгын байгууллагууд эвлэлдэн нэгдэж, хамтран ажиллах, харилцан туршлага солилцох ажлыг өргөжүүлэх,

Хүүхдийн нийгмийн оролцоог хөгжүүлэхэд чиглэсэн төрөл бүрийн сургалт,

сурталчилгаа тогтмол зохион байгуулах,

Төрийн бус байгууллагууд хамтран нийгмийн үйлчилгээний төрөл бүрийн (мод тарих, ойжуулах, түүх дурсгалын зүйлийг хамгаалах, тохижуулах, ганц бие өндөр настанд туслах зэрэг) хөтөлбөрүүдийг хөрөнгийн бага үүсвэрээр зохион байгуулах,

**Хүүхдийн эрхийн хэрэгжилтэд хяналт тавих, зохицуулах талаар:** НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтэд олон нийтийн хяналт тавих Хүүхдийн эрхийн хороог байгуулж ажиллах,

Хүүхдийн сайн сайхны төлөө үйл ажиллагааг төрийн бүх шатны байгууллага, олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, иргэд бүх талаар дэмжин хамтран ажиллах зэрэг болно.

### III Хэсэг

#### Хүүхдийн иргэний эрх ба эрх чөлөө

Монгол Улс Үндсэн хуульдаа: Иргэний ардчилсан нийгмийг хөгжүүлэхээр тунхаглаж, эрх зүйт төрийг дээдэлж байна.

Өмнөх илтгэлээс хойш хүүхдийн эрх, эрх чөлөө, тэдний эсэн мэнд амьдрах, сурч боловсрох, хөгжих, хамгаалуулах эрхүүдийг хангахтай холбоотой дараах хуулийг батлан гаргалаа.

- |   |                      |
|---|----------------------|
| 1. Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хууль | 1994 оны 7 сарын 8   |
| 2. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль              | 1996 оны 5 сарын 7   |
| 3. Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль           | 1998 оны 1 сарын 22  |
| 4. Нийгмийн халамжийн тухай хууль                     | 1998 оны 11 сарын 12 |
| 5. Харьяатын тухай хууль                              | 1995 оны 6 сарын 5   |
| 6. Боловсролын тухай багц хууль                       | 1995 оны 6 сарын 13  |
| 7. Гэр бүлийн тухай хууль                             | 1999 оны 6 сарын 11  |
| 8. Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль         | 2000 оны 12 сарын 7  |

Хүүхдийн эрхийн талаар илтгэлд заавал дурдах зүйлийн тодруулга: Үүнд:

#### Хүүхдийн тухай тодорхойлолт

##### 1 дүгээр зүйл

Хүүхдийн эрхийн тухай конвенцийн заалттай зарчим, үзэл санаа адил байгаа учир 18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ. Хүүхдийн насны хязгаар конвенцийн тодорхойлолттой тохирч байна.

Монгол Улсын Харьяатын тухай хуулийн 7 дугаар зүйлд зааснаар хүүхдийн эцэг, эх хоёулаа буюу тэдний хэн нэг нь Монгол Улсын харьяат бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгаа эцэг, эх нь тогтоогдоогүй бол хүүхэд Монгол Улсын харьяат байна гэжээ.

- Эцэг, эхийн зөвшөөрөлгүйгээр хууль эрх зүйн болон эрүүл мэндийн зөвлөгөө авах насыг хуульд тодорхой заагаагүй байна.
- Албан ёсоор зохих түвшингийн боловсрол заавал эзэмшсэн байх талаар
- Боловсролын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 2-ын 3-д 17 хүртэл насанд нь суурь боловсрол заавал эзэмшүүлэх, суралцах хүсэл сонирхлыг нь хааж боогдуулахгүй байхыг;
- Үндсэн хуулийн 16.7-д Сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгохыг;
- Боловсролын тухай хуульд боловсролын үндсэн зарчим, төрийн бодлогод бүх нийтийн ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгох, хүүхэд сурч боловсрох бүх нөхцлийг хангах, боловсроход адил тэгш эрх эдлэх, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг баримталж байна.

**Эцэг, эхийн зөвшөөрөлгүйгээр эмчилгээ,  
мэс засал хийлгэх насны талаар**

- Эрүүл мэндийн тухай хуулийн 34.2-д нарийн төвөгтэй оношилгооны арга хэрэглэх, мэс засал хийхийн өмнө тухайн иргэнээс, 18 насанд хүрээгүй хүүхэд, сэтгэцийн гүнзгий хямралтай өвчтөний тухайд түүний эцэг, эх, гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийнх нь зөвшөөрлийг авахыг;

**Хагас, бүтэн өдрөөр ажилд орох нас,  
хүүхдийн эрхэлж үл болох хөдөлмөр**

- Хөдөлмөрийн хуулийн 71.1-д долоо хоногийн ажлын цаг нь 14-15 насны ажилтанд 30 цаг хүртэл, 16-17 насны ажилтанд 36 цаг хүртэл байхыг;
- Хөдөлмөрийн хуулийн 58.1-д 18 насанд хүрээгүй ажилтны цалин хөлсийг цагаар, эсхүл хийснээр нь бодож, ажлын өдрийн хорогдуулсан цагт нь ногдох үндсэн цалинг нэмж олгохыг;
- Үндсэн хуулийн 16-д Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ. Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүйг;
- Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 2-д Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг болохыг тус тус тодорхойлсон байна.
- Хөдөлмөрийн хуульд хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг тусгай бүлэг (8 дугаар бүлэг, 109 дүгээр зүйлийн 1,2,3,4,5,11-д) болгон оруулж, заалтыг хэрэгжүүлэхээр ЭМНХЯ-ны сайдын 1999 оны 204 дугаар тушаалаар насанд хүрээгүй хүнийг ажиллахыг хориглосон ажлын байрны 14 төрлийн 100 гаруй жагсаалт гарсан.

### **Гэрлэх нас**

- Гэр бүлийн тухай хуулийн 6.1–д харшлах шалтгаангүй бол 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн эрэгтэй, эмэгтэй хоёр буюу Монгол Улсын иргэн нь гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй харилцан зөвшөөрөлцсөнөөр Монгол Улсад гэрлэж болохыг тус тус заасан байна.  
Бэлгийн харьцаанд орохыг зөвшөөрсөн насыг хуулиар нарийвчлан заагаагүй боловч Эрүүгийн хуулийн 110 дугаар зүйлд 16 насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдвэл гэмт хэрэгт тооцохоор заасан байна.

### **Цэрэгт алба хаах нас**

Зэвсэгт хүчинд сайн дураараа орох насыг хуулиар тогтоогоогүй байна.

- Албан журмаар цэргийн албанд элсэх насыг Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9. 2–д 18–25 насны Монгол Улсын иргэн эрэгтэйчүүдийг цэргийн жинхэнэ албанд татахыг заасан.
- Зэвсэгт мөргөлдөөнд оролцох насны талаар хуульд заалт байхгүй.

### **Эрүүгийн хариуцлага хүлээлгэх нас**

- Эрүүгийн хуулийн 9.1 –д гэмт хэрэг үйлдэхийн өмнө 16 насанд хүрсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг;
- Эрүүгийн хуулийн 9.2–д 14–16 хүртэл насны этгээд зөвхөн бусдыг алах, бусдын бие махбодид хүнд буюу хүндэвтэр гэмтэл санаатай учруулах, хүчиндэх, бусдын эд хөрөнгийг хулгайлах, булаах дээрэмдэх, хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг санаатай устгах, гэмтээх, хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар танхайрах, зам харилцаа, тээврийн хэрэгслийг гэмтээх гэмт хэрэг үйлдсэн бол түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг;

### **Эрх чөлөөг нь хязгаарлах, баривчлах, тусгаарлах, шоронд хорих нас**

- Эрүүгийн хуулийн 22.8–д Хөнгөн буюу хүндэвтэр гэмт хэрэгт анх удаа хорих ял шийтгүүлсэн буюу хүнд буюу онц хүнд гэмт хэрэгт гурван жилээс дээшгүй хугацаагаар анх удаа хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй эрэгтэйчүүд, түүнчлэн хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй эмэгтэйчүүдийн хорих ялыг жирийн дэглэмтэй хүмүүжил хөдөлмөрийн сургуульд эдлүүлэхээр оногдуулахыг;
- Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 383–д Насанд хүрээгүй этгээдийг албадан саатуулах, түүнчлэн түүнд таслан сэргийлэх арга хэмжээ болгож түүнийг цагдан хорьж болно. Албадан саатуулах ба цагдан хорихоор арга хэмжээ авагдсан насанд хүрээгүй этгээдийг насанд хүрсэн хүмүүс ба шийтгэгдсэн насанд хүрээгүй хүмүүсээс тусгайд нь байлгавал зохихыг, 384–т дээрх арга хэмжээнээс гадна түүнийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хяналтад шилжүүлэх, 385–д насанд хүрээгүй этгээдийг

мөрдөн байцаагч ба шүүхэд эцэг, эх буюу хууль ёсны төлөөлөгчөөр дамжуулан дуудах, 386–д насанд хүрээгүй хүмүүсийн үйлдсэн хэргийг тусгаарлах, 387–д тэднийг байцаахад сурган хүмүүжүүлэгчийг оролцуулах (16 нас хүртэл заавал), 388–д насанд хүрээгүй яллагдагч, түүнийг эцэг, эх буюу бусад хууль ёсны төлөөлөгч оролцуулахыг тус тус тодорхойлжээ.

- 1996 оны Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуульд хорих ял ногдуулах шүүхийн шийдвэрийг хойшлуулах, хянан харгалзах болон насанд хүрээгүй ялтны дэглэм, орон байрны асуудал тусгагдсан байна.

**Цаазаар авах болон бүх насаар нь хорих ял  
оноох насны хязгаар**

- Эрүүгийн байцаан шийтгэх хуульд 18 нас хүрээгүй хүүхэд, жирэмсэн эмэгтэйг цаазаар авахгүйг;

**Иргэний болон эрүүгийн хэргийн талаар  
шүүхэд мэдүүлэг өгөх нас**

- Эрүүгийн байцаан шийтгэх хуульд 16 нас хүрээгүй гэрчид хэргийн талаар мэдэх бүх зүйлээ үнэн зөв мэдүүлэхийн чухлыг тайлбарлан өгнө. Харин гэрчлэхээс татгалзах буюу зайлсхийх, санаатайгаар худал гэрчилбэл хүлээлгэх хариуцлагын талаар урьдчилан сануулахгүй. Байцаалтыг эхлэхдээ гэрч нь сэжигтэн, яллагдагч хохирогчтой ямар харилцаатай болохыг тогтоож, гэрчийн биеийн байцаалттай холбогдох бусад зүйлийг тодруулахыг, гэрчийг байцаах ажиллагаа нь ямар хэргийн талаар дуудагдаж ирсэн, тэр хэргийн талаар мэдэх бүх зүйлийг яриулахаас эхэлнэ. Гэрчээс мэдүүлэг өгч дууссаны дараа түүнд асуулт тавьж болно. Харин хөтлөх маягаар асууж болохгүйг;
- Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 158 дугаар зүйлд 16 хүртэлх насны гэрчийг байцаахдаа сурган хүмүүжүүлэгчийг оролцуулна. Хэрэв шаардлага байвал түүний эцэг, эх буюу хууль ёсны бусад төлөөлөгч, эсхүл ойрын төрөл садны хүмүүсийг оролцуулж болохыг;
- Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 47 дугаар зүйлд насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг шийдвэрлэхэд өмгөөлөгчдийг заавал оролцуулахыг,
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлд эрх зүйн чадамжгүй болон зарим буюу хэсэгчилсэн чадамжтай хүний эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг түүний хууль ёсны төлөөлөгч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь шүүхэд хамгаалах бөгөөд тэд өөрийн бүрэн эрхийг нотлох баримт бичгийг шүүхэд үзүүлнэ гэж заасныг,
- Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 279 дүгээр зүйлд 16 нас хүрээгүй гэрч буюу мөн шүүхийн үзэмжээр 16–18 хүртэлх насны гэрчийг байцаахад сурган хүмүүжүүлэгчийг ирүүлнэ. Хэрэв шаардлагатай байвал насанд хүрээгүй хүмүүсийг эцэг, эх буюу хууль ёсны бусад төлөөлөгчдийг дуудаж болохыг;
- Дурдсан хүмүүс хуралдаан даргалагчийн зөвшөөрөлтэйгөөр гэрчид асуулт тавьж болно. Хэргийн үнэнийг тогтооход шаардлагатай байвал шүүхийн тогтоол,



шүүгчийн захирамжаар насанд хүрээгүй гэрчийг шүүгдэгчийн оролцоогүйгээр байцааж болохыг;

- Шүүгдэгчийг шүүх хуралдааны танхимд орж ирсний дараа гэрчийн мэдүүлгийг танилцуулж, түүнд тэрхүү гэрчид асуулт тавих бололцоо олгохыг;
- 16 нас хүрээгүй гэрчийг шүүх байлгах шаардлагатай гэж үзээгүй бол түүнийг байцааж дууссаны дараа шүүх хуралдааны танхимаас гаргахыг;
- Иргэний хуулийн 12 дугаар зүйлийн 1.2–д эрхийн чадвар, чадамжийг хуулиар тогтоосон журмаас гадуур хязгаарлах буюу хасаж болохгүйг; Эрхийн чадвар, чадамжийг хязгаарлах буюу хасахад чиглэсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байхыг тус тус заажээ.

**Эцэг, эхийн зөвшөөрөлгүй шүүх, түүнтэй адилтгах эрх мэдэл бүхий байгууллагын өмнө гомдол гаргах, хариу авах боломжтой насны хязгаар**

- Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 155–д гэрчийг зарлан дуудах хуудсаар дуудна. Зарлан дуудах хуудсыг гэрчид гардуулна. Насанд хүрээгүй гэрчийг эцэг, эх буюу түүний хууль ёсны төлөөлөгчөөр дамжуулан дуудна. Өөр журмыг гагцхүү хэргийн байдлаас шалтгаалан хэрэглэж болохыг;
- Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 156–д 16 нас хүрээгүй гэрчид хэргийн талаар мэдэх бүх зүйлээ үнэн зөв мэдүүлэхийн чухлыг тайлбарлан өгнө. Харин гэрчлэхээс татгалзах буюу зайлсхийх, санаатайгаар худал гэрчилбэл хүлээлгэх хариуцлагын талаар урьдчилан сануулахгүйг;
- Иргэний хуулийн 10.1–д Бага насны буюу арван дөрвөн насанд хүрээгүй хүмүүсийн хийх хэлцлийг түүний нэрийн өмнөөс хууль ёсны төлөөлөгч эцэг, эх, асран хамгаалагч хийхийг;
- Иргэний хуулийн 10.2–д Бага насны хүмүүс өөртөө хохиролгүй бөгөөд хиймэгц биелэх, ахуйн чанартай жижиг хэлцэл хийж болохыг;
- Иргэний хуулийн 11.1–д Насанд хүрээгүй буюу арван дөрвөөс арван найм хүртэлх насны хууль ёсны төлөөлөгч эцэг, эх, харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр хэлцэл хийхийг;

**Захиргааны болон шүүхийн үйл ажиллагаанд оролцох нас**

- Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.2 –д 14–өөс 18 хүртэлх насны (насанд хүрээгүй) хүмүүс өөрийн эрх, эрх чөлөө хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлоо шүүхэд биечлэн хамгаалах эрхтэйг;

**Хүүхдийн хувийн зөвшөөрлийг заавал авч шийдэх асуудлууд**

(нэр өөрчлөх, гэр бүлийн харилцаанд өөрчлөлт оруулах, үрчлэх, халамжлагч өөрчлөх)

- Гэр бүлийн хуулийн 22.1–д Гэрлэлтээ бүртгүүлээгүй эцэг, эх хамтарч, эсхүл хүүхдийн эцэг, эх болох нь тогтоогдоогүй эцэг буюу эх өөрөө өргөдөл гаргасан бол иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллага эцэг, эхийг тогтоохыг;
- Гэр бүлийн хуулийн 23.1–д Хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, төрөл

- садангийн хүн, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллага буюу 14 нас хүрсэн хүүхдийн хэн нэгний өргөдлийг үндэслэн эцэг, эхийг шүүх тогтоохыг;
- Гэр бүлийн хуулийн 27.1-д Хүүхдийг орон сууц, хувцас, хоол ундаар байнга санаатай гачигдуулсан, хөдөлмөрийг нь зүй бусаар ашигласан, гуйлгачлуулсан, орон гэрээсээ дайжуулсан, гадуурхсан хүний эцэг, эх байх эрхийг зургаан сар хүртэл хугацаагаар шүүх хязгаарлаж болохыг;
  - Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 12.2-д Эцэг, эх тусдаа амьдрах болсон, гэрлэлтээ цуцлуулсан нь тэднийг хүүхдээ хүмүүжүүлэх үүргээс чөлөөлөгдөхгүйг;
  - Гэр бүлийн хуулийн 27. 2-д Эцэг, эх байх эрхийг хязгаарлах тухай нэхэмжлэлийг эцэг буюу эх нь, эсхүл төрөл, садангийн хүн, бусад иргэн, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллага шүүхэд гаргах эрхтэйг;
  - Гэр бүлийн хуулийн 29.2-д Хүүхдийг эцэг, эхэд нь буцааж өгөх нь түүний эрх, ашиг сонирхолд харшлахаар байгаа бол шүүх хүсэлтийг хэрэгсэхгүй болгож болно. Хэрэв хүүхэд долоон нас хүрсэн бол түүний саналыг харгалзан үзэхийг;
  - Гэр бүлийн хуулийн 30.1 –д Эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан (хүүхдээ хаях, санаатай төөрүүлэх, тарчлаан зовоох, худалдах, барьцаалах, биеийг нь үнэлэх, шунахай зорилгоор ашиглах, эрх зүйн зөрчилд татан оруулах зэргээр), хүүхэдтэйгээ удаа дараа хэрцгий харьцсан, бэлгийн харьцаанд оруулахаар завдсан, оруулсан, сэтгэл санааны хүнд дарамтад байлгасан, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үүргээс санаатай зайлсхийсэн, согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэдэг хүний эцэг, эх байх эрхийг шүүх хасаж болохыг;
  - Гэр бүлийн хуулийн 30.4-д Эцэг, эх байх эрхээ хасуулсан хүний хүүхдийн эрх, ашиг сонирхол хөндөгдөхгүй хэвээр үлдээхийг;
  - Гэр бүлийн хуулийн 32.3-д Эцэг, эх байх эрх сэргээх нь хүүхдийн эрх, ашиг сонирхолд харшилж байгаа нь тогтоогдсон бол эцэг, эх байх эрхээ хасуулсан хүний эцэг, эх байх эрхийг шүүх долоон нас хүрсэн хүүхдийн саналыг харгалзан сэргээхгүй байж болохыг;
  - Гэр бүлийн хуулийн 55.4-д Долоон нас хүрсэн хүүхдээс өөрийнх нь зөвшөөрлийг авахыг;
  - Гэр бүлийн хуулийн 55.5-д Эцэг, эх байх эрхээ хасуулсан хүний хүүхдийг энэ тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш зургаан сарын дараа үрчлүүлж болохыг;
  - Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 5.1-д Хүүхэд төрмөгцөө нэр авах эрхтэйг;
  - Гэр бүлийн хуулийн 14.5-д Гэрлэгчид гэрлэлт цуцлах үед хүүхдээ хэний асрамжид үлдээх, түүний болон хөдөлмөрийн чадваргүй эхнэр, нөхрөө тэжээн тэтгэх, хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө хуваах тухайгаа тохиролцож болохыг;
  - Гэр бүлийн хуулийн 14.6-д Гэрлэгчид тохиролцоогүй бол хүүхдийн нас, эцэг, эхийн халамж, ахуйн нөхцөл бололцоо, ёс суртахууны байдал, хүчирхийлэл үйлдсэн эсэхийг нь харгалзан хүүхдийг эцэг, эхийн хэн нэгний асрамжид

үлдээх, тэтгэлгийн хэмжээг тогтоох, хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг хуваах асуудлыг шүүх шийдвэрлэхийг;

- Гэр бүлийн хуулийн 14.7-д Хүүхэд долоо ба түүнээс дээш настай бол асрамжийн асуудлыг шийдвэрлэхэд түүний саналыг харгалзан үзэхийг зөвшөөрчээ.

Төрсөн эцэг, эхийн талаар мэдээлэл авах нас хуульд нарийвчлагдаагүй.

**Өв залгамжлах нас, өмч хөрөнгөтэй холбоотой асуудлыг шийдэх,  
эвсэл холбоо байгуулах нас**

- Иргэний хуулийн 405.4-д Гэрээслэгч нь бүх эд хөрөнгөө өөр этгээдэд гэрээслсэн тохиолдолд өвлүүлэгчийн насанд хүрээгүй буюу хөдөлмөрийн чадваргүй, түүнчлэн түүнийг нас барсан хойно төрсөн хүүхэд, түүний асрамжид байсан хөдөлмөрийн чадваргүй нөхөр (эхнэр), төрүүлсэн ба үрчилсэн эцэг, эх, хууль ёсны бусад өв залгамжлагч хуульд зааснаар өвлөвөл зохих хөрөнгийн гуравны хоёроос багагүй хэсгийг заавал өвлөнө. Ийнхүү заавал өвлөгдвөл зохих хэсгийн хэмжээг тодорхойлохдоо өвлүүлэгчийн хуваарьт болон дундаа хамтран өмчлөх эд хөрөнгийн оногдох хэсгийг оролцуулан тооцохыг;
- Иргэний хуулийн 98.2-д Гэр бүлийн нэг гишүүнд оногдох эд хөрөнгийн хэмжээ нь насанд хүрээгүй, хөдөлмөрийн чадваргүй бүх гишүүнийг оролцуулан нийт гишүүдэд адил байхыг заажээ;

**Шашин шүтлэг сонгох, шашны сургалттай сургуульд явах нас**

- Үндсэн хуулийн 16.15-д Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэйг,
- Боловсролын тухай хуулийн 15.6-д Шашны сургуульд суралцагчдад иргэний суурь боловсрол эзэмшүүлэх харилцааг энэ хууль болон Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулиар зохицуулахыг,
- Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 8-д Шашны боловсролыг шашны сургууль, гэрийн сургалтаар олгохыг,
- Төрийн харьяалал бүхий сургууль, байгууллагуудад шашны сургалт, цугларалт зохион байгуулахыг хориглоно. Энэ заалт нь шашны соёл, мэдлэг ухааны өв уламжлалын тухай шинжлэх ухааны сургалтад үл хамаарахыг,
- Шашны сургуульд суралцагчдад иргэний суурь боловсрол олгохыг тухайн сургууль хариуцахыг,
- Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Засгийн газраас баталсан журмын дагуу үүнд шаардагдах зардлын тодорхой хэсгийг гаргаж, багшлах боловсон хүчээр ханган мэргэжлийн хяналт тавихыг,
- Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 3-т Аливаа шашныг шүтэх буюу эс шүтэх нь тухайн хүний итгэл үнэмшлийн хэрэг байна. Иргэний шашин шүтэх, эс шүтэхэд албадах, эрх чөлөөг нь хязгаарлан хориглохыг хуульчилжээ.

**Согтууруулах ундаа болон бусад хяналт зөвшөөрөлтэй зүйл хэрэглэх нас**

- Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 8-д Сургуулийн сурагчид, 18 нас хүрээгүй хүмүүст согтууруулах ундаа хэрэглэх боломж олгохыг санаачлан зохион байгуулах, энэ зорилгоор орон байр ашиглуулах, мөнгөн туслалцаа үзүүлэхийг тэдгээрийн эцэг, эх, төрөл, садан, асран хамгаалагчид болон багш нарт хоригложээ.

**Ажил хөдөлмөр эрхлэх насны доод хэмжээ заавал эзэмших**

**боловсролын настай хэр дүйцсэн байдлын хувьд**

- Хөдөлмөрийн хуулийн 110.1-д Насанд хүрээгүй хүнийг эмнэлгийн үзлэгт орсны дараа ажилд авах бөгөөд түүнийг 18 насанд хүртэл нь хагас жил тутам эмнэлгийн үзлэгт хамруулахыг,
- Хөдөлмөрийн хуулийн 110. 2-д Насанд хүрээгүй ажилтныг шөнийн буюу илүү цагаар, түүнчлэн нийтээр амрах баярын болон долоо хоногийн амралтын өдөр ажиллуулахыг хориглохыг,
- Хөдөлмөрийн хуулийн 110. 3-д Насанд хүрээгүй ажилтныг хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлтэй ажилд ажиллуулахыг хориглохыг,
- Хөдөлмөрийн хуулийн 110.4-д Хөдөлмөрийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний баталсан хэмжээнээс илүү хүнд ачааг насанд хүрээгүй ажилтнаар өргүүлэх, зөөлгөхийг хориглохыг заажээ.

**Эрэгтэй, эмэгтэй хүүхдийн хувьд хууль эрх зүйн насны ялгаа бий эсэх**

- Монголын Улсын Үндсэн хуулийн 11-т Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдралд, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаалахаар хуульчилжээ.

**Овог, эцгийн нэр, нэр өөрчлөсний бүртгэл**

- Иргэний бүртгэлийн тухай хуулийн 18.1-д Иргэний овог, эцгийн нэр, нэр өөрчилснийг өргөдөл гаргагчийн оршин суугаа эсхүл оршин байгаа болон төрснийг бүртгэсэн газрын Засаг даргын захирамжийг үндэслэн бүртгэхийг,
- Иргэний бүртгэлийн хуулийн 18.2-д Бага насны болон шүүхээс эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон иргэний овог, эцгийн нэр, нэр өөрчлөх асуудлыг түүний хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрлөөр бүртгэхийг тус тус хуульчилсан байна.
- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд (2.5-9 дүгээр зүйлүүд) хүүхдүүд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг эдлэхийн зэрэгцээ эцэг, эхээ хайрлах, бусдыг хүндэтгэх, тэдэнд туслах, эх орон, байгаль орчноо хамгаалах, суурь боловсрол эзэмших, төрийн хууль ёсыг сахиж, ард түмний өв уламжлалыг дээдлэн хүндэтгэх, эрүүл мэндээ хамгаалах, авьяас

чадвараа хөгжүүлэх үүрэгтэйг тодорхойлж, мөн 10 дугаар бүлэгт төр, нийгмийн оролцоог тусгай бүлэг болгон оруулсан байна. “Хүүхдийн нийгмийн халамж” гэсэн бүлгийн дагуу нийгмийн халамжид хамаарахгүй хүүхэд байхгүйг;

- Үндсэн хуулийн дагуу хүүхдийн амьд байх эрхийг хангах явдлыг төр, гэр бүлийн үүрэг байхыг;
- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд хүүхдийн эрх, тэдгээрийн журамт үүрэг, эрхийг хамгаалахад төр, олон нийтийн оролцоо, хүүхдийн эрхийг хамгаалах байгууллага, түүний чиг үүрэг болон хүүхдийн эрхийг хамгаалах хууль тогтоомж зөрчсөн буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тогтоохыг,
- Садар самуун явдалтай тэмцэх тухай хуульд эротик кино, дүрс бичлэг, жүжиг, бүжгийн жүжгийг 18 нас хүрээгүй хүн үзэхгүй байх, эротик хэвлэл, ном зохиолыг олон нийтийн газар 18 насанд хүрээгүй хүнээр худалдуулах, худалдахыг хориглохыг,
- Нийгмийн халамжийн тухай хуулиар хүн амын ихэнх хэсэгт хамаарах эх, хүүхэд, ахмад настан тахир дутуу хүн, нэн ядуу амьдралтай иргэнд тэтгэвэр, тэтгэмж олгох, хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлэх чиглэлээр тэдний амьжиргааг дээшлүүлэх, түүнчлэн хүүхэд төрүүлсэн, бүтэн өнчин хүүхэд үрчилсэн эцэг, эх болон ихэр хүүхдэд тэтгэмж олгохыг тус тус хуульчилсан байна.

Хүүхдийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийг амьдралд хэрэгжүүлэхэд бэрхшээл их байна. Тухайлбал иргэний эрх зүйн боловсрол, хуульд хандах хандлага, хэрэгжүүлэх чадвар харилцан адилгүйгээс хүүхдийн эрхийг зөрчих тохиолдол түгээмэл байдаг.

Насанд хүрээгүй хүмүүсийн үйлдсэн гэмт хэргийг 2000 онд 1999 оныхтой харьцуулахад хүний амь хохироосон хэрэг 7,0 хувь, бусдын өмчийг хулгайлах хэрэг 10,0 хувь, дээрмийн хэрэгт 11,0 хувь, залилан 30,0 хувь, бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэрэг 14,0 хувиар тус тус өссөн байна. Нийт гэмт хэргийн 59 хувь нь хулгай, 17 хувь нь танхайн гэмт хэрэг эзэлж байна. Гэмт хэрэгт 2000 онд холбогдсон хүүхдийн 71,0 хувь буюу 1049 нь ажил сургуульгүй хүүхэд эзэлж байна.

Согтуугаар гэмт хэрэг үйлдэх явдал өсвөр үеийнхний дотор жил бүр өсөх хандлагатай байна. Хүүхдүүд бүлэглэн гэмт хэрэг үйлдэх явдал орон нутагт харьцангуй их бөгөөд 2000 онд гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн 75,8 хувь нь орон нутгийн хүүхдүүд байна.

Мансууруулах бодис, хорт эм хэрэглэх, охид биеэ үнэлэх, хүчирхийлэлд автах зэрэг гэмт хэргийн тоо ч өсөж байна. Хүүхдийг садар самуунд уруу татах гэмт хэрэгт 1995 онд 5 хүн, 1999 онд 12 хүн холбогдсон тоо байна.

**Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн тоо  
(сүүлийн 10 жилээр)**

	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000
Бүгд	733	885	1220	1361	1132	1397	1474	1447	1547	1465

**Шүүхээр ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийн судалгаа**

Он	Нийт хүн	Үүнээс: 14– 18 нас	Хорих ял оноосон	Торгууль
1995	13332	888	172	116
1996	9534	844	122	61
1997	10791	1063	383	72
1998	14527	1028	155	80
1999	14255	857	96	37
2000	14234	990	109	27

**IV хэсэг**

**Хүүхдийн гэр бүлийн орчин, түүнийг орлох халамж, үйлчилгээ**

Монголчууд нуган хөвүүнээ эрийн цээнд хүрэхэд шинэ гэр барьж, ам бүл тусгаарлан мал хөрөнгө таслан өгч айл гэр болгодог уламжлалтай. Монгол айл гэрийн доторх хөдөлмөрийн хуваарь, зохион байгуулалт бичигдээгүй хууль мэт нарийн чанд оноолттой байсан боловч сүүлийн хагас зуунд нилээд өөрчлөгдөж байна. Үүнд өрнө, дорнын хот, суурингийн хэв маяг нөлөөлж байгаа юм.

Гэр бүлд дунджаар 2.1 хүүхэд оногдож байна. Нийт 541.1 мянган өрх, гэр бүлийн 51.9–52.5 хувь нь хотод амьдрах бөгөөд хүн амын өсөлт сүүлийн жилүүдэд 1.4–1.7 хувь байна. Бүртгүүлсэн гэр бүл 1998 онд 27.8 мянган болж 1995 оныхоос 2 мянган хүнээр буурсан байна. (Эх сурвалж:ҮСГ.1999)

Дэлхийн банкнаас 1995 онд явуулсан Хүн амын амьжиргааны түвшин тогтоох анхны судалгаагаар 36 хувь нь, ҮСГ–ын 1998 онд явуулсан хоёр дахь судалгаагаар 35.6, үүнээс хот суурин газар 39.4, хөдөө 32.6 хувь нь ядуу байгааг тогтоосон байна. Судалгаагаар 849.8 мянган хүн амьжиргааны доод түвшингээс доогуур амьдарч байгаа нь 1995 оныхоос 21.8 мянгаар нэмэгдсэн байна. (Эх сурвалж: Амьдралын түвшинг тодорхойлох 1998 оны судалгаа)

Алслагдсан аймаг, сумын болон олон хүүхэдтэй, эмэгтэй тэргүүлэгчтэй өрх ядууралд илүүтэй (тухайлбал ядуу өрхийн 24.6 хувь нь эмэгтэй тэргүүлэгчтэй) өртөж байна. Төрөөс үнэ төлбөргүй үзүүлж байсан үйлчилгээний хүрээ багассан нь эдгээр өрхийн байдлыг хүндрүүлсэн юм.

Амьдралаас харахад эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг чинээлэг өрхүүд ядуу өрхөөс илүү хүртэж байна. Хүн амын 48 хувийг эзэлдэг хөдөөгийн малчдын хүүхдийн сургууль завсардалт нэлээд өндөр байгаа нь сургалтын чанар, багшлах боловсон хүчний дутагдалтай байдал, сургуулийн нэмэгдэл зардал их байгаатай холбоотой юм.

Хүн амын суурьшил, ажил эрхлэлт зэргээс хамаарч хүн амын сууцны төрөл,

хэрэглээ ялгаатай байна. Хөдөөд дийлэнх нь гэр сууцанд, хот суурин газрын тодорхой хэсэг нь орон сууцанд амьдрах бөгөөд хот газарт оршин суугч ядуучуудын дийлэнх нь гэрт амьдарч байна. Энэ нь орон сууцны хүрэлцээ хангамж, түүний зардал, төлбөрөөс шууд хамаарч байна. Гэр бүлийн гишүүдийн харьцаатай холбоотой хүүхэд үрчлэх, гэр бүлдээ асран хүмүүжүүлэх, тэжээн тэтгэх, асран хамгаалах харилцааг зохицуулсан Гэр бүлийн тухай хуулийг 1999 оноос шинэчлэн баталж хэрэгжүүлж байна. Суурин газрын гэр бүлд хүүхэд амьдрах нөхцөл дээрдэж байна. Гэвч ихэнх айл өрхийн амьдрал хүнд байгаа нь нийгмийн олон сөрөг үзэгдлийн шалтгаан болж байна. Гэр бүлийн тулгамдсан асуудлаас болж гэр бүлээ цуцлах, хүүхдээ өнчрүүлэх, хаяж төөрүүлэх, зодож дээрэлхэх, хүчирхийлэх, амь насыг нь егүүтгэх зэрэг бусармаг үзэгдэл өсөж байна. Гэр бүлд зориулсан сэтгэл зүйн зөвлөлгөө, үйлчилгээ түүнийг хэрэгжүүлэх мэргэжлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчид үгүйлэгдэж байна.

Гэр бүлийн асуудалд хамаарах **Конвенцийн 1, 2, 4, 5, 9–11, 18–21, 25, 27, 39** дүгээр зүйлүүдийг хэрэгжүүлэх эрх зүйн харьцааны байдлыг холбогдох хуулиас тодруулбал:

Үндсэн хуулийн 16.11–д:

Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй иргэн тэгш эрхтэйг, гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэхийг, гэр бүл, эх, нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаалахыг баталгаажуулсан юм.

Гэр бүлийн хуулийн 26.2–т эцэг, эхийн үүргийг:

- Хүүхдээ эрүүл чийрэг өсгөн бойжуулах, сэтгэхүйн хувьд төлөвшүүлэх
- Хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх
- Хүүхдээ үндэсний ёс заншил, уламжлалаа дээдлэх үзлээр хүмүүжүүлэх
- Суурь боловсрол эзэмшүүлэх, хөдөлмөрийн анхны дадлага олгох
- Хүүхдийн эрхийг хамгаалах үүргээ биелүүлэхэд нь туслахаар тусгажээ.

Гэр бүлийн хуулийн 69–д асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүргийг:

- Асрамж дэмжлэгтэй байгаа хүнийг хоол хүнс, орон сууцаар хангах, асран сувилах
- Асрамж дэмжлэгтэй байгаа хүний эрх, ашиг сонирхлыг хамгаалах
- Асрамж дэмжлэгтэй байгаа хүний мөнгөн хөрөнгө, үнэт цаас, бусад баримт бичгийг банканд хадгалуулах
- Асрамж дэмжлэгтэй байгаа хүний үл хөдлөх хөрөнгө, мал, банкны мөнгөн хадгаламж, бусад үнэт зүйлийг өөрт нь зориулан захиран зарцуулах, орон сууц хөлслөх гэрээг цуцлах, тухайн хүний нэрийн өмнөөс шинээр аж ахуй эрхлэх, эрхэлж байгаа аж ахуйн ажлыг зогсоохдоо тухайн сум, дүүргийн Засаг даргаас зөвшөөрөл авах
- Хүлээсэн үүргийнхээ дагуу жил бүр сум, дүүргийнхээ Засаг даргад тайлагнах
- Асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь энэ зүйлд заасан үүргээ биелүүлэхдээ асрамж дэмжлэгтэй байгаа (бага насны хүүхэд, сэтгэцийн өвчтэйгөөс бусад) хүний саналыг харгалзана гэж заажээ.

Гэр бүлийн хуулийн 23–т:

Хүүхдийн эцэг, эхийг шүүхийн журмаар тогтоох, 25.4–т гэр бүл хүүхдийн ашиг сонирхол зөрчилдөж байгаа нь тогтоогдвол сум, дүүргийн Засаг дарга хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах төлөөлөгчийг томилох, 25.6–д хүүхдээ тэжээн тэтгэх бололцоогүй эсвэл түүнээс зайлсхийсэн хүний хүүхдийн эрх, ашиг сонирхлыг сум, дүүргийн Засаг дарга хамгаалах, 25.9– д сум, дүүргийн Засаг дарга нь хүнд нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж, түүнийг гэр бүлдээ авч асран хамгаалахаар хүсэлт гаргасан иргэнд шилжүүлэх, шилжүүлэх боломжгүй бол сум, дүүргийн Засаг дарга нь асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгох, үрчлүүлэх, хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэхийг тус тус тодорхойлжээ. Мөн хуулийн 27, 28–ийн дагуу хүүхдийг хоол хүнс, орон сууцаар санаатай гачигдуулсан, орон гэрээсээ дайжуулсан, гадуурхсан бол эцэг, эх байх эрхийг нь 6 сар хүртэл хугацаагаар шүүх хязгаарлаж болох, тэр нэхэмжлэлийг шүүхэд эцэг, эх, төрөл садангийн хүн, иргэн, хүүхдийн эрхийг хамгаалах байгууллага, Засаг дарга гаргаж болохыг заасан байна.

Гэр бүлийн хуулийн 74–д Хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх тухай:

- Хүнд нөхцөлд байгаа бага насны буюу насанд хүрээгүй хүүхдийг иргэн гэр бүлдээ авч, өөрийн зардлаар асран хүмүүжүүлж болохыг;
- Хүүхдийг асран хүмүүжүүлэхдээ нийгмийн халамжийн байгууллага болон асран хүмүүжүүлэхээр хүсэлт гаргасан иргэний хооронд тодорхой хугацаагаар гэрээ байгуулахыг;
- Гэрээнд хүүхдийг асрах, хүмүүжүүлэх, боловсрол олгох нөхцөл, холбогдох халамжийн байгууллагын эрх, үүрэг, асран хүмүүжүүлэгчид олгох урамшил, бусад хөнгөлөлт, гэрээ дуусгавар болгох үндэслэл, үр дагаврыг;
- 7 нас хүрсэн хүүхдээс өөрийнх нь зөвшөөрлийг авахыг;
- Энэхүү үйл ажиллагаанд нийгмийн халамжийн байгууллага хяналт тавихыг;

Гэр бүлийн хуулийн 33–т:

Эцэг, эх нь хүүхдийг хууль бусаар авсан хүнээс хүүхдээ эргүүлж авахыг шаардах эрхтэй, хэрэв маргаан гарвал эцэг, эх нь эрхээ шүүхэд хандаж хамгаалуулахыг тодорхойлж, мөн хуулийн 38–д эцэг, эхийн хүүхдээ насанд хүртэл болон насанд хүрсэн ч хөдөлмөрийн чадваргүй бол тэжээн тэтгэх үүрэгтэйг, тэрхүү үүргээ тохиролцох болон шүүхийн тогтоолоор тодорхойлж хэрэгжүүлэхийг;

Гэр бүлийн хуулийн 39–д:

Асран хүмүүжүүлэх байгууллагад байгаа хүүхдэд олгогдсон тэтгэлгийг тухай байгууллагын дансанд шилжүүлэхийг;

Гэр бүлийн хуулийн 7 дугаар бүлэгт

Хүүхэд үрчлэх, үрчлүүлэх харилцааг тодорхойлсон байна. Энэ талаар эртний уламжлалтай орны хувьд дотооддоо элдэв бэрхшээл бага ч нээлттэй нийгмийн дагуу Гаагийн конвенцид нэгдэн Гэр бүлийн тухай хуулийн дагуу гадаадын иргэнд Монгол



Улсын харьяат хүүхдийг үрчлэх шинэчилсэн журмыг мөрдөж байна. Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг 1997–1998 онд үрчлүүлээгүй бөгөөд сүүлийн үед нэмэгдэх хандлагатай байна. Хууль тогтоомжийн дагуу дотооддоо хүүхэд үрчлэх, үрчлүүлэх асуудлыг сум, дүүргийн Засаг дарга, гадаадын иргэн, Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэх асуудлыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Гадаадын иргэдийн асуудал эрхлэх зөвлөл шийдвэрлэж, үүнийг үндэслэн иргэний бүртгэлийн байгууллага бүртгэлийг хийж байна. Иргэний бүртгэлийн байгууллагын мэдээгээр сүүлийн 3 жилд 1998 онд Японд 1, АНУ–д 1, 1999 онд Англид 1, АНУ–д 1, Германд 4, Солонгост 7, Өмнөд Африкт 1, 2000 онд Канадад 1, АНУ–д 4, Германд 1 хүүхэд тус тус үрчлэгдсэн байна.

Монгол Улс, ОХУ–ын Засгийн газар хоорондын 1975 оны Хоёрдмол харьяалал үүсэх асуудлыг арилгах тухай хэлэлцээрээр Монгол Улс, Оросын Холбооны Улсын харьяат холимог гэр бүлээс төрсөн хүүхдийн Монгол Улсын харьяаллыг сонгохдоо хүүхдийн зөвшөөрлийг авсны үндсэн дээр эцэг, эх нь тохиролцож шийдвэрлэхээр журамлажээ.

Гэр бүлийн хуулийн 15–1.2–т Гэр бүл цуцалсан ч хүүхдээ тэжээн тэтгэх үүрэг эцэг, эхэд хэвээр үргэлжлэн, тэтгэлгийн хэмжээг эцэг, эх тохиролцож буюу шүүхийн журмаар тогтооно. Манайд эхчүүд хүүхдээ авах нь олонтоо. Хүүхдийн тэтгэвэр авдаг эмэгтэйчүүдийн тоо ҮСГ–аас гаргасан судалгаагаар 1995 онд 7023, 1996 онд 7705, 1997 онд 3561, 1998 онд 3025 байна. Судалгаагаар тэтгэлэг авах хүүхдийн тоо огцом буурсан нь гэр бүл салалт буурсан бус, тэтгэлэг төлөх эрэгтэйчүүдийг олж авах нь бэрхшээлтэй холбоотой байж болох юм. Албан ёсны гэрлэлт, гэр бүлийн бүртгэл нь эрх зүйн хэм хэмжээ бөгөөд хүүхэд гэрлэгсдийн хувийн болон эд хөрөнгийн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой. Үүргээ биелүүлээгүй эцэг, эхийн хооронд хүүхдийн эрх ашиг хохирч, нийгмийн хамгаалал алдагдан хүүхдийн эрхийн зөрчлийг хурцатгах гол нөхцөл болсоор байна. Энэ нь гэр бүлийн нийгмийн шинжтэй асуудалд хандах төрийн тогтвортой бодлого, оролцох арга хэрэгсэл хангалтгүй, гэр бүлтэй холбоотой асуудлаар мэдээлэл, судалгааны сан бий болоогүй нөхцөл байдалд хийсэн бодитой дүн шинжилгээ ховор, гэр бүлийн төлөө үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын мэдээлэл солилцоо, хамтын ажиллагаа сул байгаатай холбоотой байна.

Жендэрийн тэгш бус байдлыг нилээд судалж байна. Үүнд уламжлалт зан үйл, шашин, эрэгтэйчүүдийг хүндлэх ёсны ойлголт хамаардаг хэдий ч эмэгтэйчүүд мэргэжил боловсролтой болсон, эдийн засгийн хувьд бие даасан байдал нь илүүтэй нөлөөлж байна. Ажиллах хүчний тэн хагасыг эмэгтэйчүүд эзэлдэг атлаа өрх толгойлсон эрэгтэйчүүдийн 21 хувь нь ядуу болсон байхад эмэгтэйчүүдийн 44 хувь нь ядуу гэсэн мэдээлэл байна.

Гэр бүлийн хүчирхийлэл нийгмийн анхаарал татах хурц асуудал боллоо. Жишээ нь Захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу 1995–1998 онд баривчлагдсан хүмүүсийн 77.7–94.6 хувь эрэгтэйчүүд бөгөөд үүний 45.2–50 хувь нь гэр бүлийн тайван байдлыг алдагдуулсан хэрэг зөрчил гаргажээ. Жишээ нь 1996 онд Улаанбаатар хотын Баянгол дүүргийн шүүхээр арга хэмжээ авагдагсдын 63.3 хувь нь эхнэрээ зодсон хэргээс болжээ.

Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн хамгаалах байранд өнгөрсөн 5 жилд нийт 627 эмэгтэй 638 хүүхдийн хамт түр байрласан байна. Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдийн аюулгүй байдлыг хангах байр хүрэлцээгүй учир хандсан бүхэнд

үйлчилгээ үзүүлэхэд хүнд байдаг байна. Гэр бүлийн хуульд хүчирхийлэлтэй холбоотой тодорхой зүйл бий боловч хохирогчийг хамгаалах эрх зүйн хамгаалалт, хүчирхийлэгчдэд хүлээлгэх хариуцлагын оновчтой тогтолцоо хангалтгүй байна.

Гэр бүл дэх элдэв зөрчил хүүхдийг орон гэрээсээ дайжихад хүргэж байна. Энэ үзэгдэл төмөр замын бүсийн төв суурин газар байсан бол сүүлийн үед ихэнх аймагт нэмэгдэж ийм хүүхдийн тоо сүүлийн 5 жилийн эхэнд 3700–д хүрсэн баримт бий. 2000 онд нийслэл дэх халамжийн төвүүдэд 646 хүүхэд байна. Тэдний 43.6 хувь нь эмэгтэй, бүгд засаг захиргааны бүртгэлгүйн улмаас харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээ авах эрх нь хязгаарлагддаг юм. Тайлангийн хугацаанд түүнийг шийдвэрлэх талаар дорвитой арга хэмжээг хэрэгжүүлж чадсангүй.

Хараа хяналтгүй хүүхдүүд өдөрт нь захаар явж хэд гурван төгрөгийн ажил хийж, захын лангууны бараанаас хулгайлах, булаах зэргээр хүнс хоол олохоос гадна хог түүх нь ч элбэг. Тэднийг садар самуунд уруу татах, бэлгийн замаар ашиглах, охид биеэ үнэлэх, хүүхдийн хөдөлмөрийг мөлжих, гэмт хэргийн золиос болгох зэрэг ноцтой зөрчлүүд тойрохгүй байна. Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр (1 рес)–ийн дэмжлэгээр Монголын хүүхэд залуучуудын хөгжлийн төв, МУИС–ийн Хүн ам зүйн сургалт судалгааны төвийн хамтран явуулсан “Биеэ үнэлэгч охидын байдал, хандлага” судалгаанд оролцсон 70 орчим охидын 38.9 хувь нь тэнэмэл болсноос, 33.3 хувь нь бага байхдаа бэлгийн хүчирхийлэлд өртсөнөөс 16.7 хувь нь бусдын ятгалгаар биеэ үнэлж байгааг тодорхойлжээ.

Хүүхдээ хаясан эцэг, эх, гэр бүлийг хуулийн дагуу хариуцлага тооцоход эдийн засгийн чадваргүй, амьд явахын төлөө өдөр хоногийг өнгөрөөж байгаа эцэг, эхийг хорьж шийтгэх боломжгүй байна. Хуулийн дагуу эцэг, эхийн эрхийг хязгаарлаж, хасаж болох авч шүүхийн практикт гараагүй байна. Хараа хяналтгүй хүүхдэд гэр бүлийн халуун дулаан орчин, эцэг, эхийн хайр халамж илүү хэрэгтэй нь ойлгомжтой. Гэвч халамжийн төвүүдэд хүүхдийг эхтэй нь цуг авдаггүй. Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хуулийг Улсын Их Хурлаас 1994 онд батлан, Засгийн газрын 1996 оны 91 тогтоолоор “Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах байрны дэглэм, журам”–ыг гарган, байрны нөхцөл, дэглэм, түр байрлуулах хугацаа, хүүхэд хүлээн авах, хүлээлгэн өгөх журмыг тогтоосон юм. Түүний дагуу нийслэлийн цагдаагийн газрын харьяанд хараа хяналтгүй хүүхдийн хаяг тогтоох, шалган хуваарилах байрыг ажиллуулж байна. Мөн Нийслэлийн Засаг даргын шийдвэрээр 140 хүүхдийн ортой Хөдөлмөр сургалт, хүмүүжлийн төв байгуулж Улаанбаатар хотын төсвөөс санхүүжиж байна.

Засгийн газрын 1997 оны 9 дүгээр сарын 22–ны өдрийн 193 дугаар тогтоолын дагуу өнчин, эцэг, эхийн хараа хяналтаас гарсан болон нэн ядуу айл өрхийн хүүхдийн байдлыг сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах, зохих шатны боловсрол олгох, гэр бүлийг дэмжихэд анхаарч байна. НҮБ–ын Хүүхдийн сан Засгийн газартай 1997–2001 онд хамтран ажиллах гэрээний дагуу Гэр бүл хүүхдийн сайн сайхны төлөө хөтөлбөрийн хүрээнд хараа хяналтгүй болон тахир дутуу хүүхдэд туслах чиглэлээр жилд дунджаар 100.0 гаруй мянган ам. долларын дэмжлэг үзүүлсэн байна. Хүнд нөхцөлд байгаа хүүхдүүдэд туслах, аж байдлыг сайжруулах чиглэлээр гадаадын буяны байгууллага, сайн санаат иргэд, сүм хийд өргөн үйл ажиллагаа явуулж байна. Нийслэлд байрладаг

гадаадын санхүүжилттэй 20 гаруй халамжийн төв жилд дунджаар 500–700 хүүхдийг асрамжлан тэдэнд нийгмийн зохих үйлчилгээг хүргэж зарим нааштай үр дүн гаргасныг тэмдэглэж байна. Тухайлбал Дэлхийн зөн олон улсын байгууллага Монголд 1997 оноос хүнд нөхцөлд амьдарч байгаа гудамжны хүүхэдтэй идэвхтэй ажиллаж байна. Английн Хүүхдийг ивээх сан 1996 оноос нийслэлийн захын хороололд нийт 125 хүүхдийн 5 хот айлыг зохион байгуулан түүнийгээ Дархан–Уул, Дорнод, Сэлэнгэ, Төв, Орхон аймагт салбарлан 200 гаруй хүүхдийг хамарч нийгмийн халамж үйлчилгээ үзүүлж байна. Кристина Нобелийн хүүхдийн сан 1998 оноос хараа хяналтгүй хүүхдийг асарч өсгөх хотхон ажиллуулж байна.

Цаашид халамж, асрамжийн төвүүдийн үйл ажиллагааг жишиг үзүүлэлтэй харьцуулан үнэлэх, орон нутгийн засаг захиргаатай хамтран хүүхдийг гэр бүлийн ахуй орчинд нь буцаахад чиглэсэн үйл ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай байгаа юм.

Өнчин хүүхдийг асрамжлах чиглэлээр улс, орон нутаг, томоохон аж ахуйн нэгжийн төсвөөр гурван төв ажиллаж, тэнд 500 гаруй хүүхэд өсөж хүмүүжиж байна. Өнчин хүүхэд, залуучуудыг дэмжих чиглэлээр Сос Киндердорф олон улсын байгууллагаас өнчин хүүхдийг асрамжлах хүүхдийн тосгон Монголд ажиллуулахаар Засгийн газартай урт хугацааны гэрээ байгуулан ажиллаж байна.

Харин халамжийн чиглэлээр төрийн үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдийн бүртгэл судалгааг цэгцлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг хүүхдээр үнэлүүлэх, өнчин хүүхдийг насанд хүрмэгц орон байраар хангах, ажил хөдөлмөр эрхлэхэд туслах ажлын хэрэгжилт хангалтгүй байгаад дүгнэлт хийж байна.

Өнгөрсөн хугацаанд хүүхэд, гэр бүлд үзүүлж ирсэн нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээ нь хүнд нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх чиглэлээсээ илүү нөхөн сэргээх хэлбэрээр хэрэгжиж байв. Энэ нь зардал, цаг хугацаа их шаарддаг, хүссэн үр дүнд хүрээгүй хэдий ч нийгмийн халамжийн үйлчилгээг зөв бодлого, зохион байгуулалтаар хэрэгжүүлэх явдал нийгмийн хамгааллын салбарын тулгамдсан зорилт болж байна.

## **V хэсэг**

### **Хүүхдийн эрүүл мэндийн байдал**

Улсын хэмжээнд эмнэлгийн 17.974 ор ажиллаж байгаагийн 15.8 хувь нь буюу 2857 нь хүүхдийн эмнэлгийн ор эзэлж байна. Манай улсад 10000 хүн амд ноогдох хүүхдийн мэргэжлийн эмч 3.0, өрхийн эмч 1.8, ерөнхий мэргэжлийн эмч 3.6 ногдож байгаа бөгөөд эдгээр нь хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байна.

Хүүхдэд эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээг хөдөөгийн нөхцөлд сумын эмнэлэг, багийн бага эмч нар, аймгийн төв, нийслэлд эрүүл мэндийн төв, өрхийн эмнэлгүүд үзүүлж байна.

Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сан, олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байгаа амьсгалын цочмог халдвар, суулгалт өвчинтэй тэмцэх, хөхөөр хооллох, хүүхдийн өвчний цогц удирдлага төсөл болон

Дархлаажуулалтын хөтөлбөрүүдийн үр дүнд хүүхдийн эндэгдэл өндөртэй орноос дунд зэргийн эндэгдэлтэй орны эгнээнд орсон байна. Нялхсын эндэгдлийн бүтцэд уушигны үрэвсэл, нярайн эмгэг, суулгалт өвчин, халдварт өвчин, осол гэмтэл голлох байрыг эзэлж байна. Хүүхдийн эндэгдлийн шалтгааныг өвчний нэршлээр үзвэл 5 хүртэлх насанд уушигны үрэвсэл (44.1 хувь), суулгалт өвчин (27.3 хувь), гаж хөгжил (11.1 хувь), ураг нярайн үеийн тархины эмгэгшил (9.1 хувь), бүтэлт ба амьсгал бөглөрөл (8.4 хувь) эхний 5 байрыг эзэлж байна.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар хангалтгүй, нэн шаардлагатай эм тариа дутагдалтай, хүүхдийн эрүүл мэндийн төлөө эцэг, эхийн анхаарал сул байх нь хүүхдийн өвчлөл, эндэгдэлд нөлөөлсөөр байна.

Сүүлийн 3 жилийн хүүхдийн эндэгдэлд хийсэн судалгаанд нийт нас баралтад хоног болоогүй болон гэрийн эндэгдлийн эзлэх хувь 46.7 (Д.Малчинхүү 2000) байгаа нь нас барсан 5 хүүхэд тутмын хоёр нь эмнэлгийн тусламж авч чадаагүй гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Үндэсний статистикийн газар НҮБ-ын Хүн амын сангийн хамтран хийсэн судалгаагаар 5 хүртэлх насны хүүхдийн нас баралт (62 хувь) статистикийн мэдээнээс зөрөөтэй гарсан. Иймд эх, хүүхдийн эндэгдлийг бүртгэх тайлан мэдээний тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.

Цаашид ураг нярайн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах, эмч нарын хүүхдийн анагаахын мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх, 2 хүртэл насны хүүхдийн эрүүл мэндийн хяналтыг тогтмолжуулах, суурь өвчнөөс сэргийлэх, түүнийг цаг алдалгүй эмчлэхэд анхаарал тавина.

Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалахад эцэг, эх, сайн дурынхныг бэлтгэх, сургах, мэдээллээр хангахад эрүүл мэндийн сургалтын тогтолцоо шаардлагатай байна.

**Дархлаажуулалт.** Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тарилгатай халдварт өвчнийг танадах идэвхтэй сүлжээг нэвтрүүлсний дүнд дээрх өвчин жил бүр буурч, хөдөө орон нутагт вакцинжуулалтын хамралт 5–10 хувиар нэмэгдсэн байна. 1993 оноос улаан бурхан өвчнөөр хүүхэд эндээгүй, 1994 оноос сахуу, улаан бурхан, менингитийн дэгдэлт гараагүй. Халдварт саа (полимиелит) өвчнийг устгасан ДЭМБ-ын батламжийг 2000 онд хүлээн авлаа.

ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сан, Японы Засгийн газрын олон улсын хамтын ажиллагааны байгууллагын 3.5 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг олон улсын стандартын шаардлага хангасан вакцин, вакцин хадгалах, тээвэрлэх, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжид зориулан, бүх аймаг, хотыг бага оврын цахилгаан үүсгүүр, мотоцикл, автомашинаар хангав. Тайлангийн хугацаанд олон улсын байгууллагаас 2.502 мянган ам.долларын дархлаажуулалтын вакцин, бэлдмэлийг авч төсвийн санхүүжилтээр жил тутам 220–250 сая төгрөгийг орон нутагт хүргэх, зохион байгуулах ажилд зарцуулж байна.

1994–2000 онуудад сүрьеэгийн вакциныг 337538 сахуу, хөхүүл ханиад, татрангийн вакциныг 319150, улаан бурхны вакциныг 315456, вируст гепатит В-ийн эсрэг вакциныг 309760, халдварт саагийн вакциныг 318017 хүүхдэд тус тус хийж, жилд дунджаар холбогдох салбарын 2500 хүнийг сургалтад хамруулав.

Халдварт өвчнөөс сэргийлэх, тарилгатай халдварт өвчнийг тандан судлах, хяналтад авах арга зүй зэрэг 18 төрлийн гарын авлага, ном, товхимлыг нийтийн хүртээл болголоо. Хэвлэл, радио, телевизээр тогтмол сурталчилгаа хийж, жил бүрийн 5,10 дугаар сард вакцинжуулалтын 10 хоногийг зохион байгуулдаг юм.

2000 онд нэг хүртэлх насны хүүхдэд заавал хийх дархлаажуулалтын хамралт БЦЖ 97.2 хувь, халдварт саа 93.9 хувь, сахуу, татран, хөхүүл ханиад 94.1 хувь, улаан бурхан 92.4 хувь, вируст гепатит В 92.6 хувь байна. Дархлаажуулалтын үндэсний хөтөлбөрийн 1993–2000 оны зорилт биелсэн. Гэвч товлотт вакцинд хамрагдвал зохих хүүхдийн 60 орчим хувь нь хамрагдан заавал нэмэлт вакцинжуулалт шаардах нь хүн амын шилжих хөдөлгөөн их, вакцины тухай эцэг, эхийн мэдлэг тааруу, алслагдсан нутгийн дэд бүтэц, зам тээвэр, холбоо муу зэрэгтэй холбоотой юм. Одоогоор сэргийлэх тарилгад хамрагдсан байдал дархлал тогтцын үр дүнд лабораторийн шинжилгээтэй тархвар судлалын үнэлгээ хангалтгүй байна. Халдварын голомт бүхий нутгийн хүн ам, тодорхой ажил мэргэжлийн хүмүүсийг сэргийлэх вакцины ач холбогдлыг хэрэглэгчдэд ойлгуулах, сургалт сурталчилгаанд зардал дутмаг байна. Мөн төсвийн эх үүсвэргүйгээс А вируст гепатит, гахайн хавдар гэх мэт хүн амын дунд элбэг тохиолдож байгаа, халдварт өвчнүүдээс сэргийлэх вакцинаар хангах боломж бүрдээгүй байна.

Өсвөр насны хүүхэд залууст эрүүл мэндийн боловсрол олгох сургалтын агуулга, арга зүйд анхаарч багш нарт зориулсан эрүүл мэндийн гарын авлагыг хэд хэдэн чиглэлээр боловсруулав. Ерөнхий боловсролын сургуулиудын дунд “Эрүүл мэндийг дэмжигч сургууль” хөдөлгөөнийг өрнүүлэх, Эрүүл мэндийг дэмжигч загвар сургуулийг дэмжих зорилгоор ДЭМБ-ын төслөөс 8.2 сая төгрөгийн багаж, тоног төхөөрөмжийг олголоо. Сурагч, өсвөр үеийнхний эрүүл мэнд Үндэсний хөтөлбөрийг 1997 оноос, Хүн амын эрүүл мэндийн боловсрол хөтөлбөрийг 1998 оноос тус тус хэрэгжүүлж “Эрүүл мэнд” хичээлийг 1998–1999 оноос ЕБС-ийн анги бүрт 12 цагаар заах боллоо.

БЗХӨ/ДОХ-оос сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны үндэсний стратегийг хэрэгжүүлэх нь ирээдүйн иргэдийг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Жил бүр ДОХ-той тэмцэх өдөрт зориулан компанит ажил зохион байгуулж, амьдархуйн чадвар буюу хүний зан үйлийг өөрчлөхөд чиглэсэн ном, тараах хэрэглэгдэхүүнийг түгээдэг. БЗХӨ/ДОХ-оос сэргийлэх үйл ажиллагаанд олон нийт, иргэний байгууллагуудыг татан ороцуулах, оюутан сурагчдыг “Үе тэнгийнхний сургагч багш”-аар бэлтгэн тэднээр дамжуулан өргөн сургалт явуулж байна.

Мэдээлэл, сургалт, сурталчилгааны материал боловсруулахад олон улсын зарим байгууллагын дэмжлэгийг авч 150 материалд үнэлгээ өгч, тухайн материалын хэрэгцээ, зорилтот бүлэгт хүрэх боломжийг тодорхойллоо.

БЗХӨ/ДОХ-оос сэргийлэх, сурталчилгааны боловсон хүчний чадавхийг дэмжин арга зүйч, эмч нарын бүсийн сургалтыг явуулж, гарын авлага материалууд бэлтгэхэд анхаарч байна. БЗХӨ/ДОХ-оос сэргийлэх асуудлыг анхаарч Засгийн газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Хүүхдийн сан, Хүн амын сан, ДЭМБ-тай хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурсан. Энэ нь БЗХӨ/ДОХ-оос сэргийлэх үндэсний бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хандивлагчидтай хамтран ажиллах бололцоог нээв. 1999–2000 онуудад 15–25 насны залуучуудын ХДХВ/ДОХ/ БЗХӨ-ний талаарх мэдлэг, хандлага, дадал

үндэсний судалгааг явуулж, дүгнэлт гаргав. ХДХВ-ийн халдвар авсан 2 тохиолдол 1992, 1997 онд бүртгэгдсэн бөгөөд ХДХВ-ийн халдварын түвшин бага байгаа болохоор сүүлийн жилүүдэд өртөмтгий бүлгийнхнийг шинжилгээнд түлхүү хамруулахад анхаарч байна. ХДХВ-ийн шинжилгээ 1999 онд хийгдсэн хүмүүсийн 64.3 хувь (13672) нь эмэгтэйчүүд, үүний 2537 нь жирэмсэн эмэгтэйчүүд байлаа.

**Хоол тэжээл.** Дөрвөн сар хүртэлх насны хүүхдийн 97.5 хувь нь дан хөхөөр хооллож байгаа бөгөөд энэ насны хүүхдийн дунд хоол, тэжээлийн дутагдал буюу тураал 2 хувьтай байна. Хүүхдийг нэмэгдэл хоолонд орж эхлэх үеэс хүүхдийн хоол, тэжээлийн дутагдал буюу уураг илчлэгийн дутагдал нас ахих тутам нэмэгдэж (4–6 сартайд 2 хувь, 7–12 сартайд 7 хувь, 1–2 хүртэл насанд 16 хувь, 2–3 хүртэл насанд 18 хувь хүртэл) байна. Үүний шалтгааныг хоол, тэжээлийн байдалтай холбон үзэхэд анхны нэмэгдэл хоолонд 75 хувь нь хугацаандаа, 13.8 хувь нь хожуу, 7.9 хувь нь эрт (3 сараас өмнө) орсон байна. Хэдийгээр ихэнх хүүхэд хугацаандаа нэмэгдэл хоолонд орж байгаа боловч 54.4 хувь нь анхны нэмэгдэл хоолонд зутан, бантангаар орж, энэ төрлийн хоолыг нэг нас хүртэл өгдөг, илчлэг, тэжээллэг чанараар дутмаг цөөн нэр төрлийн (гурил, мах, ус) бүтээгдэхүүнийг удаан хугацаагаар байнга хэрэглэж байгаа нь хоол, тэжээлтэй холбоотой бусад өвчлөл, сульдаа, цус багадалт, хоол, тэжээлийн архаг дутагдалд орох нэг хүчин зүйл болж байна. Судалгаанаас үзэхэд бага, дунд боловсролтой эхчүүдийн хүүхэд уураг, илчлэгийн дуталт өртөх нь 3.5 хувиар их байна. Өрхийн нэг хүнд ноогдох мөнгөн орлого нь 30000–аас доош орлоготой өрхийн хүүхдүүд хоол, тэжээлийн дуталт орох үзэгдэл үүнээс дээш орлоготой өрхийн хүүхдүүдтэй харьцуулахад 5 дахин их байна. Хот, хөдөөгийн байдлаар авч үзэхэд эдгээр үзүүлэлтүүд хөдөөд хотоос илүүтэй байгаа нь хүнсний бүтээгдэхүүний хангамж, нэр төрлийн хомсдолтой холбоотой байж болно. Нөгөө талаас нийгмийн хүчин зүйл болох амьжиргааны түвшин доогуур байх, эхчүүдийн хоол, тэжээлийн талаарх мэдлэг боловсрол хангалтгүй байх нь хүүхдийн асаргаа, сувилгаа, хоол тэжээлийн хангалтад муугаар нөлөөлж байна.

Өмч хувьчлалд 1997 оноос хүүхдийн сүүн тэжээлийн үйлдвэр, хүүхдийн сүү борлуулах цэг буюу хүүхдийн сүүний газрууд өртсөн байна. Хэдийгээр хүүхдийг хөхөөр хооллох бодлого амжилттай хэрэгжиж өндөр үр дүнд хүрсэн боловч өсөн торниж байгаа хүүхдийг нэмэгдэл хоолоор хангаж чадахгүй байна.

**Тахир дутуу хүүхдийн байдал.** Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны судалгаагаар манай улсын сургуулийн насны хүүхдүүдийн 8 хувь буюу 34000 хүүхэд тахир дутуу, эмгэг согогтой байна.

Сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллага тахир дутуу хүүхдийг сүрьеэ зэрэг архаг халдварт өвчний хурц халдвартай үеэс бусад тохиолдолд эрүүл хүүхэдтэй хамт өсгөн хүмүүжүүлэхийг эрмэлздэг байна.

НҮБ-ын Хүүхдийн сангийн хөтөлбөрийн хүрээнд тахир дутуу, эмгэг согогтой хүүхдийг олон нийтийн хүчинд тулгуурлан нөхөн сэргээх, нийгэмшүүлэх үйл ажиллагааны загварыг Хан-Уул, Налайх дүүрэгт бий болгож байгууллага, иргэдийн оролцоог өргөжүүллээ.

Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу 16 хүртэлх насны тахир дутуу хүүхдээ байнга асарч байгаагийн улмаас ажил эрхэлдэггүй нэн ядуу өрхийн асран хамгаалагчид хүүхдээ асран хамгаалахад нь зориулан амьжиргааны доод түвшингийн 75 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламжийг нийгмийн халамжийн сангаас сар бүр олгодог. Тухайлбал 1999 оны байдлаар 26.3 сая төгрөгийн тусламжийг 549 өрхийн гишүүдэд олгосон байна. Нэн ядуу өрхийн 16 хүртэлх насны тахир дутуу хүүхдэд зориулалтын тэргэнцрийн үнийг нэг удаа олгодог. Тухайлбал 1999 онд 145 хүүхдэд тэргэнцэр олгож нийт 21.2 сая төгрөгийг улсаас зарцуулсан байна.

Шилжилтийн үед тахир дутуу иргэдэд ялангуяа хүүхдүүдэд үзүүлж байгаа нийгмийн хамгааллын арга хэмжээ зайлшгүй шаардлагатай боловч тэднийг өөрийнхөө амьдралыг жирийн иргэдийн адил хөтлөн, амьдралд идэвхтэй оролцогч болгон хөгжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа үгүйлэгдэж байна.

Ялангуяа өсвөр үеийнхний өвчлөлийг бууруулах, эрүүл мэндийг хамгаалахад төр захиргаа, эцэг, эх, иргэний нийгмийн оролцоог дээшлүүлэх, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээг өргөжүүлэх, хүн амын эрүүл мэндийг хянах сүлжээг бүрдүүлэхэд чиглэсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

## VI хэсэг

### Хүүхдийг тусгайлан хамгаалах арга хэмжээ

Энэ сэдэвт НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 22, 32–40 дүгээр зүйлүүд хамаарч байгаа бөгөөд эдгээр зүйл, заалтын агуулга, зарчим нь дараах хуулиудад тусгалаа олсон байна. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль
- Гэр бүлийн тухай хууль
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль
- Тамхины хор хөнөөлтэй тэмцэх тухай хууль
- Эрүүгийн хууль
- Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль
- Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль зэрэг

Насанд хүрээгүй хүмүүсийн эрхийг тусгайлан хамгаалах, тэдний эрхийг бодитойгоор эдлүүлэх явдал нь шүүх эрх мэдлийн болон хууль хамгаалах байгууллагуудын үйл ажиллагаанаас шууд хамаарч байна. Энэ нь насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, байцаан шийтгэх, шүүн таслах, ял эдлүүлэх ажиллагаанд баримталж байгаа бодлого, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа зөрүүтэй байгаатай холбоотой.

Хүүхдийн онцлогийг харгалзан гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүмүүст тусгайлсан ажиллагаа явуулахаар хуульчилсан. Жишээ нь ЭБШХ-ийн 381, 382 дугаар зүйлд насанд хүрээгүй хүмүүсийн үйлдсэн гэмт хэргийн талаар гүйцэтгэх ажиллагааг

ЭБШХ–д заасан ерөнхий журмаас гадна онцгой журмаар гүйцэтгэх тухай заасан бөгөөд энэ тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн хүүхдийн нас, амьдралын нөхцөл байдал, хүмүүжил, гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан нөхцөл, өдөөн хатгагч, хамтран оролцогч байсан эсэх, сэтгэхүйн хувьд өөрийн үйлдлийн холбогдлыг бүрэн ойлгож байгаа эсэхийг илрүүлэн тогтоох үүрэг, эрхийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллага, албан тушаалтанд олгожээ.

Хүүхдийн хэргийг шалгахдаа хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэх үүднээс насанд хүрээгүй этгээдийн эцэг, эх, түүний багш, хүмүүжүүлэгч болон хэрэгт ач холбогдол бүхий зүйлийг мэдэж болох бусад хүмүүсийг байцаах, хэрэгцээтэй бичиг баримтыг шаардан авах эрхтэй байдаг.

Түүнчлэн насанд хүрээгүй этгээдийн хувьд цагдан хорих, албадан саатуулах, таслан сэргийлэх арга хэмжээг зөвхөн онцгой тохиолдолд хэрэглэх, хэрэгжүүлэхдээ насанд хүрэгчдээс тусгаар байлгахыг хуульчилсан.

Сүүлийн жилүүдэд нийгмийн ядуурал, ажилгүйдэл, гэр бүл дэх хүчирхийлэл, гэр бүл салалт зэрэг үндсэн хүчин зүйлээс шалтгаалан сургууль завсардсан болон хараа хяналтгүй хүүхдийн тоо өсөж, насанд хүрээгүй хүмүүсээс гэмт хэрэг үйлдэх, гэмт хэрэгт холбогдох, ял шийтгүүлэх явдал буурахгүй байна.

Цагдаагийн ерөнхий газарт Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэс ажиллаж, хүүхдийн үйлдсэн гэмт хэргийг шалгах, тэднийг гэмт үйлдэлд уруу татсан, эрх ашгийг нь хохироосон гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж байна. Энэ хэлтсийн гаргасан судалгаанаас үзэхэд 1994–2000 онд гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн тоо өссөн байна.

Цагдаагийн байгууллага нь хүүхдийн үйлдсэн гэмт хэргийг байцаан шалгах ажлыг гүйцэтгэхийн зэрэгцээ хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн, ял хойшлогдсон, хорих ял эдлээд суллагдсан, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад гадуур мөрдөгдөж байгаа хүүхдүүдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нэр төрийг нь сэргээн нийгмийн амьдралд оролцуулах (нийгэмшүүлэх) зорилтыг хэрэгжүүлж холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Засгийн газраас 1999 онд батлагдсан Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр нь хууль хэрэгжүүлэх байгууллагуудын үйл ажиллагаанд ахиц өөрчлөлт гарах нөхцлийг бүрдүүлж өгсөн юм.

Шүүх хүүхдийн гэмт хэргийг шүүн таслахдаа хуулийн дээрх шаардлага, заалтад нийцүүлэхийн зэрэгцээ хүүхдэд ногдуулах ял шийтгэлийг хөнгөрүүлж үзэх боломжтой. Жишээ нь тус улсын Эрүүгийн хуулийн 36 дугаар зүйлд насанд хүрээгүй этгээд гэмт хэрэг үйлдсэн тохиолдлыг ял, хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдал гэж үзэхээр заасан, мөн 42 дугаар зүйлд анх удаа 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлж байгаа насанд хүрээгүй этгээдэд хорих ял ногдуулсан таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэхийг 2 сараас 2 жил хүртэл хугацаагаар хойшлуулж болохоор байна.

Прокурорын байгууллага нь насанд хүрээгүй хүмүүсийн тусгайлан хамгаалах хэм хэмжээг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хэрэгжиж байгаад хяналт тавьж, ЭБША–ны зөрчлийг арилгуулах онцгой эрх мэдэл бүхий этгээд бөгөөд гэмт



хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцдог юм.

Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуульд насанд хүрээгүй хоригдолд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөл журмыг тодорхойлон заасан. Тухайлбал хоригдож байгаа насанд хүрээгүй хүүхдийг ерөнхий боловсролын сургалтад бүрэн хамруулах, ялыг нь жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлэх, ердийн нийтийн байранд байлгах, илгээмж уулзалтын тоог үл хязгаарлах, амралтын цаг нь Хөдөлмөрийн тухай хуульд нийцсэн байх зэрэг нь тусгагдсан. Эдгээр хуулийн хүрээнд хүүхдийг тусгайлан хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа хэдий ч шүүх болон хууль сахиулах байгууллагын ажилд хүүхдийн эрхийг зөрчих, хүүхдэд хууль зүйн туслалцаа үзүүлж чадахгүй байх тохиолдол түгээмэл байна. Тухайлбал эрүүгийн хэргийг шалган шийдвэрлэх явцад хүмүүсийг албадан саатуулах, цагдан хорих арга хэмжээ нь манайд хамгийн түгээмэл бөгөөд бараг эрүүгийн гэмт хэрэг бүрт хэрэглэгдэж байна. Гэтэл урьдчилан хорих байрны нөхцөл нь хүний эрхийн наад захын жишиг хэмжээг хангаж чадахгүй байгаагаас хүний амь нас, ялангуяа хүүхдийн эрүүл мэнд хохирох, сөрөг үзэгдэл гардаг юм.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч, Хүний эрхийн дээд комиссар хатагтай Мэри Робинсон 2000 онд Монголд айлчлах үеэр “Урьдчилан хорих төвийн байдалтай танилцаад гонсойх сэтгэл төрсөн, жижиг байранд маш олон хүнийг хорьдог, тэнд нь гэрэлгүй, харанхуй, агааргүй, бас насанд хүрээгүй хүүхдүүд байсан нь бүр ч харамсалтай байна” хэмээснийг анхаарч насанд хүрээгүй хүүхдийг хорих нөхцөл байдлыг сайжруулахад НҮБ-ын ХС-тай хамран ажиллаж байна. Юуны өмнө хууль хяналтын байгууллагын (мөрдөн байцаах, шүүх, прокурор, цагдаа) ажилтнуудыг хүүхдийн эрхийн чиглэлээр мэргэшүүлэх, насанд хүрээгүйчүүдийн хорих ангитай хамтран ажиллах, насанд хүрээгүй хүмүүст эрх зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх, өмгөөлөгчийг ажиллуулах зэрэг асуудалд анхаарал тавьж байна.

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 25 дугаар зүйл буюу уг хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын асуудлыг авч үзэхэд гэм буруутай этгээдэд сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр захиргааны шийтгэл оногдуулдаг ч тухайлбал хүүхдийн тэтгэлэг төлөхөөс зайлсхийсэн иргэнээр төлбөл зохих тэтгэлгийг төлүүлж, түүнийг 50000 хүртэл төгрөгөөр торгох буюу 30 хүртэл хоногоор баривчлах зэргийг хэрэгжүүлж чадахгүй байна.

Хүүхдийн аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчиж байгаа зам тээврийн осолд хүүхдүүд амь насаа алдах, бэртэж гэмтэх нь түгээмэл байна. Зөвхөн 2000 онд зам тээврийн осолд өртсөн хүүхдийн 1/4 нь амь насаа алдсан байна.

Хүний эрх түүний дотор хүүхдийн эрхийг хамгаалах арга хэрэгслийг боловсронгуй болгох чиглэлээр шүүх, прокурор, цагдаа, өмгөөлөл, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагуудын үйл ажиллагааг хүний эрхийг дээдлэн хүндэтгэх зарчимд нийцүүлэн эрх зүйн хүрээнд шинэтгэл хийхийг эрмэлзэж байна.

Насанд хүрээгүй хүмүүсийг засан хүмүүжүүлэх нэг анги ажилладаг бөгөөд хорих ангийн захиргаа хоригдол хүүхдийн нөхцөл байдлыг олон улсын жишигт ойртуулан шинэчлэх зорилтыг хэрэгжүүлж байна. Сүүлийн 5 жилд насанд хүрээгүйчүүдийн хорих ангид 526 хүүхэд шинээр ял эдлэхээр шийтгэгдэн ирж, 439 хүүхэд суллагдсны 55 нь Өршөөлийн тухай хуулиар суллагдсан байна. Ангийн захиргаа хүүхдийн амьдрах ухааны

сургалтад илүү анхаарч мэргэжил эзэмшүүлэх дамжааг явуулдаг байна. Тэнд ирсэн хүүхдийн хэргийн талаар өөрсдийн яриаг сонсоход 2 бог хулгайлж 70.000 төгрөгийн хохиролтой, удаа дараа хүнсний ногоо хулгайлж 200.000 төгрөгийн хохиролтой гэх зэргээр ярьдаг нь насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай НҮБ-ын дүрмийг хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатайг илтгэж байна.

Гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлж байгаа хүүхдийн тоо буурахгүй, ихэнхдээ 3 жил хүртэл хугацааны хорих ялаар шийтгүүлэх явдал их байна. Урьд нь ялангуяа хулгайн гэмт хэрэгт ял шийтгүүлж байсан хүүхдүүд дахин гэмт хэрэг үйлдэж байгаа нь насанд хүрээгүй хүмүүст оногдуулах ялын бодлогод анхааралтай хандах, тэдний онцлог зэргийг харгалзан нийгэм олон нийтэд түшиглэсэн хүмүүжлийн арга хэмжээг хэрэгжүүлэх явдал дутагдалтай байгааг нотолж болох юм.

Засгийн газар насанд хүрээгүй хүмүүсийн эрхийг хамгаалах талаар аливаа үйл ажиллагааг иргэний нийгмийн оролцоотой хэрэгжүүлэхэд илүү анхаарч ажиллана. Хүүхдийг эх эцгийн хараа хяналт дор гэр бүлдээ засарч хүмүүжих нөхцлийг бүрдүүлэхэд гэр бүл төвд, олон нийтийн хүчийг дайчилсан үйл ажиллагааг дэмжиж, орон нутгийн засаг захиргааны байгууллага, төрийн бус байгууллагын түншлэлийн хүрээг өргөжүүлэх чиглэлийг баримтална. Эцэг, эхийн үр хүүхдийн төлөө хүлээх хариуцлагыг дээшлүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд түлхүү анхаарна.

Цаашид хүүхдийн асуудлаар мэргэшсэн өмгөөлөгч бий болгох, шүүгч, прокурор, мөрдөн байцаагч, хорих байгууллагын ажилтныг мэргэшүүлэн сургах, насанд хүрээгүй хүмүүсийн гэмт хэргийн системтэй мэдээллийн тогтолцоог дэмжих ялангуяа насанд хүрээгүй хүмүүсийн асуудлыг шүүхийн өмнө онцгойлж үзэхэд бүсийн орнуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлнэ.

## VII хэсэг

### Хүүхдийн боловсрол, хөгжил, оролцоо

Сүүлийн жилүүдэд боловсролын тогтолцоог зах зээлийн харилцаанд нийцүүлэн шинэчлэх, сургалтын агуулгыг суралцагчдын хэрэгцээнд ойртуулах, сургалтын идэвхтэй арга зүйг хэрэгжүүлэх, удирдлагын шат дамжлагыг багасгаж төвлөрлийг сааруулах чиглэлээр өөрчлөлт хийж байна.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн нийгмийн салбарт баримтлах үндсэн зорилт нь хүний хөгжлийг хангах орчныг бүрдүүлэх, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэх, нийгмийн үйлчилгээг хүртээмжтэй болгох, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чиглэж байна.

Үүнтэй холбогдуулан сайн чанарын суурь боловсролыг бүх хүнд хүргэж тогтвортой байлгах зорилгоор Засгийн газар, иргэний нийгэм, үндэсний болон олон улсын түнш нарыг нэгтгэсэн үндэсний хэмжээний түншлэл байгуулах нь ойрын үеийн зорилт болж байна.

Боловсролд хуваарилсан нийгмийн төсвийн хөрөнгийн хэмжээ, эзлэх хувь Монгол Улсын Их хурлаас 1995 онд баталсан Боловсролын тухай (шинэчлэн найруулсан) хуулийн

33 дугаар зүйлд “Боловсролын үйл ажиллагааг хэвийн явуулах шаардлагыг хангах хэмжээний төсвийг Улсын Их хурал, аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал батална. Боловсролын санхүүжилтэд улсын төсвийн жилийн орлогын 20-иос доошгүй хувийг зарцуулна” гэсэн заалтыг хэрэгжүүлж байна.

Боловсролын хуульд 1995 онд сургууль, боловсролын байгууллагад хандивласан мөнгөн хөрөнгийг орлогын албан татвараас чөлөөлөх тухай асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хуульд тусгуулсан нь боловсролын байгууллагын санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд тустай арга хэмжээ болсон юм.

**Боловсролын чанар, хүртээмж.** Тайлангийн хугацаанд сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын талаар явуулсан бодлогын нэг хэсэг нь энэ түвшингийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх явдал байв.

Монгол Улсад 1998 оныг хүртэл албан ёсоор 8 нас хүрсэн хүүхдийг сургуульд элсүүлэх эрх зүйн зохицуулалттай байсан бол 1999 оноос боломж бүрдсэн газар 6–7 настай хүүхдийг сургуульд элсүүлж болох тухай заалтыг Боловсролын тухай хуульд нэмэлт болгон оруулсан болно. Тухайлбал 1999 оны байдлаар 6 настай хүүхэд нийт элсэгчдийн 1,0 хувийг, 7 настай хүүхэд 15,7 хувь, 9 ба түүнээс дээш настай хүүхэд 14,7 хувийг тус тус эзэлж байна. Хотын сургуульд элсэгчдийн 26,0 хувь нь 6–7 насандаа сургуульд элсэж байгаа бол хөдөөд энэ үзүүлэлт 11,4 хувьтай байна. Мөн хөдөөгийн элсэгчдийн 18,0 хувь нь зохих насандаа элсэлгүй оройтон элсэж байна. Бага сургуулиас (1–4 дүгээр ангид) завсардсан хүүхэд 1995–1996 онд 43 хувь байсан бол 1998–1999 онд 25 хувь болжээ. 2000 онд бага сургуулийн насны хүүхдийн 75,6 хувь сургуульд сурч байна. Цаашилбал суурь боловсрол (1–8 дугаар анги) бүрэн эзэмшсэн хүүхдийн түвшин 1999 онд 64 хувь болсон байна.

Хичээлийн байрын 280.0 мянган суудал бүхий ерөнхий боловсролын 683 сургуульд 2000 оны байдлаар 494,5 мянган хүүхэд суралцаж байгаа нь хичээл болон хичээлээс гадуурх сургалтын ажлыг зохион байгуулах нөхцөл боломжийг хязгаарлаж байна. Өөрөөр хэлбэл хичээлийн байрын суудал нь нийт суралцагчдын 60-аад хувийг хангаж байна. Сүүлийн жилүүдэд хөдөө орон нутгаас төв рүү чиглэсэн иргэдийн шилжилт хөдөлгөөн эрс нэмэгдсэнээс Улаанбаатар, томоохон хот суурин, хот орчмын бүс нутгийн хүн амын нягтрал ихсэж сургууль 3 ээлжээр хичээллэж, анги дүүргэлт 45–50-д хүрч, хичээл сургалтын хэвийн үйл ажиллагаа алдагдахад хүрч байна.

Сурагчдын дотуур байрны зардлыг төр хариуцдаг болсон боловч хүүхдийг бүрэн суулгах байрны боломж хүрэлцэхгүй байна. Нийт сургуулийн 24 хувь болох хөдөөгийн 130 сургуулийн байр, нийт дотуур байрны 26 хувь болох 91 дотуур байрны барилга, байгууламжийн нөхцөл, халаалтын байгууламж муудсанаас өвлийн улиралд жигд ажиллах бололцоогүй байна.

Боловсролын орон нутгийн болон нэгж байгууллагын үйл ажиллагааны хувь заяа ихэнх тохиолдолд удирдлагын ажлын арга барил, тэдний удирдах ур чадвараас хамаарч байгаа учир 1999 оноос Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам боловсролын удирдах ажилтанд тавигдах жишиг шаардлагыг боловсруулан хэрэгжүүлж байна. Тухайн насныг хамарсан сургалтын хувиас харахад манай оронд суурь боловсрол олгох нас (8–15)-ны

68155 хүүхэд сургуульд суралцаж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл 8–11 насны хүүхдийн 9,1 хувь буюу 23476 хүүхэд, 12–15 насны хүүхдийн 18,3 хувь буюу 44679 хүүхэд сургуульд сурч чадахгүй байна.

Хүйсийн тэнцвэрт байдал доголдож 8–15 насны 42078 эрэгтэй хүүхэд сургуульд суралцдаггүй нь сургуулийн гадна байгаа хүүхдийн 61,7 хувь болж байна. Харин 8–15 насны 51690 хөдөөгийн хүүхэд сургуульд сурдаггүй нь сургуулийн гадна байгаа хүүхдийн 75,8 хувь болж байна. Дунд ангиас хүйсийн тэнцвэрт байдал алдагдаж 2000–2001 оны хичээлийн жилд ЕБС–д суралцагчдын 52,3 хувь нь эмэгтэй сурагчид байна. Бага ангид суралцагчдын 50,1 хувь, дунд ангид суралцагчдын 53,4 хувь, ахлах ангид суралцагчдын 59,4 хувь нь эмэгтэй сурагчид байна.

Сурагчдын сурлагын амжилт хөдөөд доогуур байна. Хөдөөгийн сумдын хүүхдийн сурлага нийслэлийн хүүхдүүдийнхээс монгол хэлээр 14,8 хувь, математикаар 22,0 хувиар тус тус доогуур байна. Бага, дунд боловсролын агуулгыг нийгмийн эрэлт хэрэгцээ, суралцагчдын авьяас сонирхолд нийцүүлэн залгамж холбоотойгоор өөрчлөн шинэчилж нийгмийн ухааны хичээлийг дарангуйлан захирах тогтолцооноос ангижруулж, ардчилсан нийгмийн иргэн төлөвшүүлэхэд чиглүүлэн өөрчлөв. Энэ түвшингийн сургалтын агуулгын өөрчлөлтийг үндэслэн бүх төрлийн хичээлийн сурах бичгийг шинэчлэх, олон хувилбартай болгох, сурах бичиг зохиох, хэвлэх, хуваарилах, ангилахтай холбогдсон дүрэм, журмыг өөрчлөн боловсронгуй болгох арга хэмжээг авснаар ЕБС–ийн сурах бичгийн 90–ээд хувийг шинэчлэв.

**Багш нарын хүрэлцээ, хангамж.** Ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарч бүх шатны сургууль, цэцэрлэгийн эрхлэгч, багш нарын нэмэгдэл амралтыг ажлын 33 өдрөөр тогтоож багш нарыг тэтгэвэрт гарахад нь нэг хичээлийн жилийн хугацааны үндсэн цалингийн хэмжээгээр буцалтгүй тэтгэмж олгож байхаар Боловсролын тухай хуульд хуульчилсан нь тэдний нийгмийн баталгаанд ач холбогдолтой арга хэмжээ болсон юм. Багш нарт 1996 оноос мэргэжлийн зэрэг, ур чадварын зэрэг нэмэгдэл олгодог болж, ЕБС–ийн бага, дунд болон цэцэрлэгийн багшийн үндсэн цалингийн ялгааг 1997 оноос эхлэн арилгав. ЕБС–ийн багш нарын дотор мэргэжлийн бус багш нар 1998–1999 оны хичээлийн жилийн байдлаар 9,1 хувийг эзэлж байна. Боловсролын шинэ агуулга, арга технологид нийцүүлэн багш нарын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн олон удаагийн сургалт–семинарыг зохион байгуулав. ЕБС, цэцэрлэгийн багш нарыг 4 жил тутам мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулж байхаар тогтоож, 1998 оноос мэргэжил дээшлүүлэх сургалтын зардлыг багш нарт эрхийн бичгээр олгодог журамд шилжүүлэв.

**Бичиг үсгийн тайлагдалтын түвшин.** Бичиг үсэгт тайлагдаагүй залуучуудын тоо өссөн нь 1990–ээд оноос хойшхи сургууль завсардалттай холбоотой. Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын дүнгээр 15 ба түүнээс дээш насны иргэдийн 97,8 хувь бичиг мэддэг үүнээс эрэгтэйчүүдийн 98,0 хувь нь, эмэгтэйчүүдийн 97,5 хувь нь бичигтэн болсон дүнтэй гарлаа. Харин 8–11 насны нийт хүүхдийн 10 хувь нь, 8–15 насны нийт хүүхдийн 6,8 хувь нь бичиг үсэг огт мэдэхгүй байна. Нэгдүгээр ангид элссэн нийт хүүхдийн 18 хувь

нь бага боловсролыг, 25 хувь нь суурь боловсрол хугацаандаа эзэмшиж чадахгүй байна. Хүүхдийг хүйсээр ялгаварлан гадуурхдаггүй ч хүүхдийн нас ахих тутам охид хөвгүүдийн сургуулийн боловсролд оролцох үйл явцад тэгш бус байдал ихсэж байна. Нэгдүгээр ангид ороходоо охид хөвгүүдийн тоо ижил харьцаатай байдаг боловч 10 дугаар ангид 62 хувь нь охид, 38 хувь нь хөвгүүд байгаа нь сургууль завсардсан хүүхдийн харьцаанд тусгалаа олжээ. Сургуулиа орхисон хүүхдийн 69 хувь нь хөдөө амьдарч байна.

Монгол Улсын Үндсэн хуульд “Бүх нийтийн ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгоно” гэсэн заалтыг үндэслэн төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуульд суралцагчдад нэг суралцагчийн нормативт зардлын хэмжээгээр сургалтын зардлыг төрөөс хариуцах тогтолцоонд шилжүүлэв.

ЕБС завсардалтыг багасгахад чиглэсэн арга хэмжээ авсны дүнд сургууль завсардагчдын тоо 1994–1995 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 4,3 хувь байсныг 1998–1999 оны хичээлийн жилд 3,4 хувь болгож бууруулав.

Хүүхдийн сургууль завсардалтыг багасгахад нөлөөлөх нэг хүчин зүйл нь эцэг, эхийн боловсролд хандах үнэлэмжийг нэмэгдүүлэх явдал юм. Энэ талаар эцэг, эхэд чиглэсэн сургалт, сурталчилгаа мэдээллийг түлхүү явуулах шаардлагатай байна. Сургуульд сурч байгаа хүүхдийг сургуулиас завсардуулахгүй байлгахын төлөө ажиллахаас гадна нэгэнт сургууль завсардсан хүүхдүүдэд боловсрол нөхөн олгох асуудал тулгарч байна. Албан бус боловсролын үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 1997 оны 116 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байна.

Монгол Улсад албан бус боловсролын тогтолцоо бүрдүүлэх ялангуяа хүн амын хэрэгцээ, сонирхол, бололцоонд тулгуурласан сургалтын агуулга, хэлбэр, арга зүйг тогтоох, албан бус боловсролын боловсон хүчин, материаллаг бааз бий болгох ажлыг гол зорилго болгон тавьсан юм. Албан бус боловсролыг хөгжүүлэх ажлыг орон даяар зохион байгуулах, хүн амын боловсролын хэрэгцээг хангах сүлжээ үүсгэн үйлчлэхэд оршиж байна.

Хүн амд боловсрол нөхөн олгох албан бус боловсролын тогтолцоо үндэсний хэмжээнд бүрэлдэж эхэлж байна. Сүүлийн 4 жилд боловсрол нөхөн олгох сургалтад 19970 хүүхэд залуучууд хамрагдан суралцаж 7877 нь зохих шатны агуулгын стандартыг хангасан гэрчилгээ, боловсролын үнэмлэх авсан байна. Боловсрол нөхөн эзэмшүүлэх сургалтаар 2000 оны байдлаар 3856 хүүхдийг ЕБС–ийн зохих ангид нь оруулж 10979 хүнд бага боловсрол, 3880 хүнд суурь боловсрол, 2237 хүнд бүрэн дунд боловсрол эзэмшүүлжээ. Энэ үйл хэрэгт НҮБ–ын Хүүхдийн сан, Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага, ОУХБ болон Монголд үйл ажиллагаа эрхэлж байгаа олон улсын байгууллагуудын дэмжлэг туслалцаа ихээхэн үүрэг гүйцэтгэж байна.

**Дунд сургууль төгсөгчдийн байдал.** ЕБС–ийн 8 дугаар анги төгсөгчийн 78,6 хувь нь 9 дүгээр ангид, 14,9 хувь нь МСҮТ–д 2000 оны байдлаар дэвшин суралцсан байна. Энэ хувийг цаашид нэмэгдүүлэх чиглэл баримталж байна. ЕБС–ийн 10 дугаар анги төгсөгчдийн дийлэнх хэсэг нь төрийн ба төрийн бус өмчийн их сургууль, коллежуудад элсэн суралцаж байгаа бөгөөд тэд бүрэн дунд боловсрол эзэмшсэний хувьд цаашид төрөл бүрийн мэргэжил эзэмших боломж харьцангуй нээлттэй байдаг гэж хэлж болно.

ЕБС–ийн 8 дугаар анги төгсөөд 9 дүгээр ангид орж чадаагүй хүүхдүүдийг мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцуулан мэргэжил эзэмшүүлж байна. Засгийн газар Техникийн болон мэргэжлийн сургалтыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг батлан 1998 оноос хэрэгжүүлж байна. Төрийн ба төрийн бус өмчийн 38 мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 1999 оны байдлаар 10765 суралцагч суралцаж байна. Барилгын мэргэжлээс бусад мэргэжлийн боловсролын сургуулиудын оюутнуудын дийлэнх нь буюу 58,6 хувь нь эмэгтэйчүүд байна.

Өнөөгийн мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн тогтолцоо өсөн нэмэгдэж байгаа хөдөлмөрийн зах зээлийн харилцаанд тэр бүр нийцэж чадахгүй байна. Энэ асуудлыг шийдвэрлэхэд зах зээлийн өнөөгийн байдлыг цэгцтэй судлах, ирээдүйн ажлын байрны хэрэгцээг төлөвлөж сурах хэрэгтэй байна. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль батлуулах замаар сургалтын шинэ хөтөлбөр, сургалтын стандарт боловсруулах шаардлага гарч байна.

**Тахир дутуу болон нийгмийн эмзэг бүлгийн хүүхэд боловсрол эзэмших боломжоор хангагдсан байдал.** Сургуулийн өмнөх ба бага, суурь боловсролын үйлчилгээний гадна орхигдсон хүүхдүүдийн боловсрол эзэмших эрхээ эдэлж чадахгүй байгаагийн үндсэн шалтгаан нь нийгэм дэх хүн амын ядууралтай шууд холбоотой юм. Эцэг, эх нь амьдралын наад захын хэрэгцээгээ хангаж чадахгүй болсны улмаас хүүхдээ сургуульд суралцуулах боломж нь хязгаарлагддаг байна. Хүүхдээ тэжээн тэтгэх, асран хамгаалах чадваргүй гэр бүлийн тоо нэмэгдэж, хүүхэд хараа хяналтгүй болох нь ихэслээ.

Сургуулийн орчинд сургалтын сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх шаардлагатай байна. Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдүүдийг нэгтгэн сургах, тэдэнд хандах нийгмийн хандлагыг өөрчлөх, боловсрол эзэмшүүлэх асуудал хоцрогдонгуй хэвээр байна. Монгол Улсын сургуулийн насны нийт хүүхдийн 4 хувь буюу 34000 хүүхэд тахир дутуу болон оюун ухааны хомсдолтой байгаагаас 37 хувь нь сургуулийн гадна байна. Хөдөө орон нутагт амьдарч байгаа эмгэг согогтой хүүхдүүд бус нутагтаа тусгай боловсролын үйлчилгээнд хамрагдах боломж хязгаарлагдмал байна. Ерөнхий боловсролын тусгай 5 сургуульд 2000 оны байдлаар 2000–гаад хүүхэд суралцаж байна.

Нийгмийн эмзэг бүлгийн болон 4 ба түүнээс дээш хүүхэд нь сургуульд зэрэг суралцдаг өрхийн нэг хүүхдийн хичээлийн хэрэглэлийг төрөөс хариуцаж байна. Энэ хичээлийн жилд нийт 35000 хүүхэд хичээлийн хэрэглэлээр үнэ төлбөргүй хангагдлаа.

Норвегийн Хүүхдийг ивээх сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Монголын Хүүхдийн эрхийн төвтэй хамтран Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны дэргэд Сургуулийн нийгмийн ажлын нэгжийг ажиллуулж байна. Тус нэгж нь ЕБС–д ажиллах нийгмийн ажилтнуудыг бэлтгэх, давтан бэлтгэх, арга зүйн туслалцаа үзүүлэх зорилготой юм. Хүүхдийн хөгжлийг дэмжих зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2000 оны 157 дугаар тогтоолоор ойрын жилүүдэд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг баталлаа. Энэ чиглэлд ЕБС–ийн дотуур байрыг ээлж дараатай засварлах, сурагчдын дүрэмт хувцсаар хангах, нэн ядуу өрхийн хүүхдийн дүрэмт хувцасны үнийг төрөөс санхүүжүүлэх, аймаг, нийслэлийн албан бус боловсролын Гэгээрэл төвийг бэхжүүлэх, сургууль завсардсан хүүхдэд суурь боловсрол нөхөн олгох, ажил мэргэжлийн чиг баримжаа,

хөдөлмөрийн дадлага олгох зэрэг үйл ажиллагааг өргөжүүлэхээр заасныг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

**Сурагчдын дотуур байр.** Нүүдлийн мал аж ахуйн амьдралын хэв загвар зонхилсон манай орны хувьд малчдын хүүхдийг сургуульд хамруулж байсан уламжлалт үндсэн аргын нэг бол хөдөө орон нутгийн сургуулийг дотуур байраар хангаж ирсэн явдал юм. Зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих шилжилтийн эхний он жилүүдэд дотуур байрны үйл ажиллагааг хэвийн явуулахад санхүүжилтийн эх үүсвэр хязгаарлагдмал байснаас олон байр хаагдсан, мөн дотуур байранд суух хүүхдүүдээс тодорхой хэмжээний мах ногдуулан авах болсон зэрэг нь түүнд хамрагдах хүүхдийн тоог эрс багасгасан юм.

Дотуур байрны сурагчид, нийт суралцагчдын 14,5 хувийг 1990 онд хамарч байсан бол 1996 онд 4,1 хувь болтлоо буурсан байна. Дотуур байрны сурагчдыг өмнөх жилтэй нь харьцуулсан жилийн түвшингээс үзэхэд 1995–1996 оны хичээлийн жилийг хүртэл тогтмол буурч байсан бөгөөд 1996–1997 оны хичээлийн жилээс эхлэн өсөх хандлага руу орж эхэлсэн байна. ЕБС–ийн дотуур байранд амьдардаг хүүхдийн тоо сүүлийн 4 жилийн хугацаанд аажим өссөөр 2000 онд 27.4 мянгад хүрсэн нь дотуур байрын нөхцөл харьцангуй дээрдсэн, сургууль завсардалт багассан, хоолны зардлыг улсаас хариуцан төлөх болсон явдал голлон нөлөөлж байна.

**Чөлөөт цагийг өнгөрүүлэх, алжаал тайлах, хүмүүжлийн ажил.** Засгийн газраас “Бүх нийтийн экологийн боловсрол” үндэсний хөтөлбөрийг батлан 1997 оноос хэрэгжүүлж байна. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Ерөнхий боловсролын сургуульд заах “Экологи”, их сургууль, коллежид заах “Экологи, байгаль хамгаалал” хичээлийн хөтөлбөрийг боловсруулж, уг хичээлийг заавал судлах хичээлийн бүрэлдэхүүнд орууллаа.

Гэгээрлийн сайдын 1998 оны 257, 275 дугаар тушаалаар Хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөр, Хүүхдэд уран сайхан, гоо зүйн мэдлэг олгоход баримтлах уран бүтээлийн жагсаалтыг батлан мөрдөж байна.

Хүүхдийн чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, тэдний хүсэл, сонирхолд нийцсэн үйл ажиллагаа зохион байгуулах арга зүйг боловсруулах шаардлагатай байна.

Монгол Улсад сүүлийн жилүүдэд нүүрэлсэн зудын гамшиг тохиолдол малчдын хүүхдэд ихээхэн сөрөг нөлөөлж байна. Зудтай байгаа аймаг, сумдын сургуулиудыг засварлах, дотуур байрны ахуй нөхцлийг сайжруулахад чиглэсэн зарим арга хэмжээг хэрэгжүүлж байгаа боловч төдийлөн үр дүнд хүрэхгүй байна. Зудын улмаас эцэг, эх нь амьжиргааны эх үүсвэр болсон мал нь цөөрснөөс хот руу чиглэсэн нүүдэл ойрын жилүүдэд үргэлжлэх төлөвтэй байна.

**Тулгамдаж байгаа асуудал.** Нийт 70.3 мянган ор бүхий 653 хүүхдийн цэцэрлэгт 79,3 мянга гаруй хүүхэд хүмүүжиж байгаа нь хүүхдийн цэцэрлэгт хамрагдвал зохих 3–7 насны нийт хүүхдийн 30 орчим хувийг хамарч байна. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангахад цэцэрлэгийн барилга, орны тоог одооныхоос нэлээд хэмжээгээр нэмэгдүүлэх шаардлага байна. Цэцэрлэгт орсон хүүхдийн тоо харилцан адилгүй байна. Нийт цэцэрлэгт хамрагдагчдын 40,7 хувь хотод бөөгнөрч,

43,2 хувь нь суурин газар, 15,9 хувь нь хөдөө байна. Малчдын хүүхэд, амьжиргааны түвшин доогуур айлын хүүхдүүд цэцэрлэгт хамрагдах боломж хязгаарлагдмал байна. Хүүхдийг зохих насанд нь боловсрол эзэмшүүлэх, боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, энэ талын үйлчилгээг хүүхэд бүрт хүргэх явдал гол зорилт болж байна. Малчдын хүүхдийн сургуульд сурах таатай орчин бүрдүүлэх чиглэлээр нэлээд ажил хийх шаардлагатай байна.

Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хөдөө орон нутгийн хүүхдүүд бүс нутагтаа боловсрол эзэмших боломж, нөхцөл хязгаарлагдмал байна. Хүүхдийн чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх, тэдний нас, сэтгэхүй, хэрэгцээ сонирхолд тохирсон төрөл бүрийн үйл ажиллагаа явуулах арга зүй бүрдээгүй байна, Тэрчлэн багш бэлтгэх, давтан бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх тогтолцоог бүхэлд нь өөрчлөн шинэчлэх үзэл баримтлал, чиг хандлага тодорхойлогдоогүй, төрийн болон төрийн бус өмчийн сургуулиар бэлтгэж байгаа багш нарын мэргэжлийн түвшин бага, дунд боловсролын хөгжлийн шаардлагыг бүрэн хангаж чадахгүй, багш нарын мэргэжил дээшлүүлэх оновчтой, үр ашигтай шинэ бүтэц бүрдээгүй, багш нарын цалин болон нийгмийн асуудал шаардлагын түвшинд хүрээгүй байна.

**Цаашдын зорилт.** Хот, хөдөөгийн сургуулиудын сургалтын орчны ялгааг багасгаж, багш нарыг тогтвор суурьшилтай ажиллуулах бодлого боловсруулан хэрэгжүүлэх;

Сургалтын агуулгын стандартыг бүрэн хэрэгжүүлхүйц боловсролын орчны стандартыг боловсруулан мөрдүүлэх;

Сургуулийн барилга, дотуур байрыг засах, өргөтгөх, шинэ сургууль барих, улмаар сургалтын орчныг сайжруулахад мэдэгдхүйц ахиц гаргах;

Сургалтын орчны стандартыг хангахуйц сургалтын хэрэглэгдэхүүн, лаборатори, тоног төхөөрөмж, цахим тооцоолуурын хангамжийг нэмэгдүүлэх;

Амьжиргааны доод түвшингээс бага орлоготой болон ядуу амьдралтай эмзэг бүлгийн өрхийн хүүхдүүд, тусгай хэрэгцээт боловсрол шаардсан хүүхдүүдийг боловсрол эзэмших тэгш боломжийг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх зэрэг болно.

Эдгээр зорилтуудыг хангахад юуны өмнө тулгамдсан болон хөгжлийн хэтийн асуудлуудад судалгаа, хяналт–шинжилгээ хийж, үнэлгээ дүгнэлт өгөх, улмаар хэрэгжүүлэх арга хэрэгслийг боловсронгуй болгоход үйл ажиллагааг чиглүүлэх болно.

**Хүүхдийн оролцооны эрхийг дэмжих чиглэл.** Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагууд 1990–ээд оноос үүссэн хөгжил нь тайлангийн хугацаанд эрс идэвхжлээ. Монголын Скаутын холбоо, Хүүхэд залуучуудын хөгжлийн төв, “Нэг ертөнц –Өсвөр үе”, Идэрчүүдийн холбоо зэрэг олон байгууллага монгол орны өсвөр үе, хүүхэд залуучуудыг нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, хөгжих, боловсрох эрхийг эдлэх нөхцөл боломжоор хангах, дэмжлэг туслалцаа үзүүлэхэд ихээхэн хүчин чармайлт гарган ажиллаж, багагүй амжилт ололт, арга туршлага хуримтлууллаа. Энэ хугацаанд хүүхдийн хөгжих, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах орчныг бүрдүүлэх талаар төр засгаас онцгой анхаарч, хэд хэдэн чухал арга хэмжээ авлаа. Энд Төрийн бус байгууллагын тухай хууль 1997 онд батлагдсан нь иргэний нийгмийн байгууллагыг дэмжих үндсэн нөхцөл боллоо.



Монголын хүүхдийн үндэсний чуулганыг 1998, 2001 онд зохион байгуулсан бөгөөд хүүхдийн өөрийн удирдлагын хэд хэдэн байгууллага шинээр үүсэн, үндэсний хүрээнд үйл ажиллагаа явуулах болов. Ерээд оны дундаас Монголын эмэгтэй скаутын холбоо, Монголын залуучуудын улаан загалмай, Монголын хүүхдийн үндэсний холбоо, Ажил эрхэлдэг хүүхдийн “Мандах” холбоо, “Нэг ертөнц-өсвөр үе”, Ахлах ангийнхны хөгжлийг дэмжих холбоо зэрэг байгууллагууд тус тус байгуулагдлаа. Тэдгээрт олон мянган хүүхэд хамрагдаж байна. Хүүхдийн эдгээр төрийн бус байгууллагууд нь тэдний үзэл бодол, санал хүсэлтээ чөлөөтэй илэрхийлэх индэр болж; нийгмийн амьдралд идэвхтэй оролцож байна.

Монголд анх удаа хүүхэд, өсвөр үеийнхний дунд НҮБ-ын “Нэг ертөнц” сэдэвт цуврал бага хурлыг Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Нийгмийн дэвшил, эмэгтэйчүүд хөдөлгөөн зохион байгуулж, 1200 гаруй хүүхэд оролцууллаа. Цуврал бага хурлууд “Хүүхдийн эрх”, “Хүний эрх”, “Нийгмийн хөгжил”, “Эмэгтэйчүүд хөгжил”, “Хүн ам, хөгжил” зэрэг сэдвээр чууллаа. Хүүхдүүд нийгмийн асуудлыг хэний ч санаанд оромгүй, нухацтай, бодитой хэлэлцэж байсан нь насанд хүрэгчдийн бахархлыг төрүүлж байв. Уг бага хурлуудад Монгол Улсын төр засгийн удирдагч, парламентын гишүүд оролцож, санал бодлоо солилцсон нь хүүхдүүдэд итгэл зүтгэл, урам зориг нэмсэн үйл явдал болов.

Хүүхдийн үзэл бодлыг төр засгийн шийдвэр гаргах түвшинд хүргэж, мөрөөр нь арга хэмжээ авахын төлөө 1998 онд “Бага парламент”, 1999 онд “Бага Засгийн газар”-ын хуралдаан зохион байгуулж, хүүхдүүдийн саналаар 2000 оныг “Хүүхдийн хөгжлийг дэмжих жил” болгон зарлаж, орон даяар бүх нийтийн хөдөлгөөн өрнүүллээ.

Ажил хөдөлмөр эрхэлдэг хүүхэд (1998), Малчин хүүхэд (1999), Авьяастан хүүхэд (2000)-ийн чуулга уулзалт зохиож, ижил нөхцөлд амьдардаг, ижил хүсэл сонирхолтой хүүхдүүд санал бодлоо солилцож, үзэл санаагаа илэрхийлэв.

Түүнчлэн Монголын Хүүхдийн урлагийн их наадам (1999), Монголын Хүүхдийн спортын их наадам (2000)-ыг анхан шатанд болон орон нутаг, үндэсний хүрээнд үе шаттай явуулсан нь хүүхэд өөрийгөө нээж хөгжүүлэх чухал нөлөө үзүүлэв. Мөн жил бүр 2-3 аймгийн хүүхдийн урлаг, уран бүтээлийн тайлан үзлэгийг улсын нийслэлд зохион байгуулж, орон нутгийн ажлыг үндэсний хүрээнд танилцуулдаг уламжлал тогтлоо.

Сүүлийн жилүүдэд Монголын нээлттэй нийгэм хүрээлэн болон бусад байгууллага хамтран ахлах насны хүүхдийн дунд мэтгэлцээн явуулж, энэ талаар тусгай төсөл ч хэрэгжүүлж байна. Тухайлбал Олон улсын хүүхдийн “Найрамдал” төвд жил бүр мэтгэлцээний сургалтын ээлж зохион байгуулж, аймаг орон нутгуудын хүүхдүүд хамтран ажиллах, харилцан туршлагаа солилцоход тусалж байна.

Монгол Улсад нийгмийн ажил 1997 оноос эхлэн шинээр үүсэн хөгжиж, одоо 10 гаруй их дээд сургуульд мэргэжлийн нийгмийн ажилтан бэлтгэж байна. Ерөнхий боловсролын сургууль бүр 2000 оноос нийгмийн ажилтантай болж, хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх, тэдний хөгжих эрхийг хангах ажилд шинэ хөшүүрэг боллоо.

Сүүлийн 5 жилд хүүхэдтэй ажилладаг төрийн ба төрийн бус байгууллагын бүх ажилтан, идэвхтэнүүд нийгмийн ажлын сургалтад бүрэн хамрагдлаа. Үүнд НҮБ-ын Хүүхдийн Сан, Английн Хүүхдийг ивээх сан, Дани-Монголын сургалт, арга зүйн төв, Дэлхийн зөн олон улсын байгууллага их дэмжлэг үзүүллээ.

Эрх нь зөрчигдөж байгаа хүүхдүүдийн санал гомдлыг хүлээн авах “Хүүхдийн утас”, “Хүүхдийн шуудан” ажиллуулж байна. Хүүхдийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор Монголын үндэсний телевизийн хүүхдийн нэвтрүүлгийн редакцыг 1999 онд “Боловсрол” студи болгон өргөтгөж хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн тоо, цагийн хэмжээг 3 дахин нэмэгдүүлэв. Мөн Монголын радиогийн хүүхдийн нэвтрүүлгийн редакцыг “Сургалт, танин мэдэхүйн редакц” болгон өргөтгөн зохион байгууллаа. Төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн идэвх санаачилгын үр дүнд хүүхдэд зориулсан ном хэвлэл, сонин сэтгүүлийн тоо, гаралт нэмэгдэж, чанар үзэмж нь сайжирлаа. Өнгөрсөн 1995–2000 онд “Би,би,би”, “Симба”, “Хөх шувуу “Үлгэрийн ертөнц “Яагаад”, “Бамбар”, “Цох”, “Нар”, “Сурлага”, “Үерхэл” зэрэг 10 гаруй сонин, сэтгүүл шинээр гарч, тогтмол хэвлэгдэж байна.

Түүнчлэн Булган, Архангай, Увс, Төв, Дорнод, Ховд, Өвөрхангай, Хөвсгөл зэрэг 12 аймаг хүүхдэд зориулсан орон нутгийн жижиг сонин гаргаж байна.

НҮБ–ын Хүүхдийн сан, үндэсний байгууллагууд хамтран 1999 онд “Өсвөр үеийн дуу хоолой” уулзалт, зөвлөлгөөн хийж, 2000 оноос “Монголын өсвөр үеийнхний оролцоо ба хөгжих эрхийн хангалт” сэдвээр хөтөлбөр, төслүүд хэрэгжүүлж эхэллээ. Хүүхэд санал бодлоо илэрхийлэн улмаар шийдвэрт нөлөөлж байна.

Скаутын холбоо, Хүүхэд залуучуудын хөгжлийн төв хамтран өсвөр үеийн хөгжих болон нийгмийн амьдралд оролцох хэрэгцээг дэс дараатай шийдвэрлэх үүднээс 2000 онд “Монголын өсвөр үеийнхний хэрэгцээг судлах судалгаа”–г явуулсан юм. Уг судалгаагаар өсвөр үеийнхний оролцоо, хөгжлийн тухай нийгмийн ойлголтыг тандан гүнзгийрүүлэх, хэрэгцээг нарийвчлан тодорхойлох, голлох хэрэгцээг судлах, тэдний хэрэгцээг оновчтой хангах асуудлаар санал зөвлөмж дэвшүүлэх, өсвөр үеийнхний оролцооны шинэ хэв загварыг бүрдүүлэх зорилтуудыг дэвшүүлсэн юм.

Өсвөр үеийнхний мэдээллийн хэрэгцээ, хүртэх боломж харилцан адилгүй байна. Тухайлбал. Ямар мэдээлэл хамгийн чухал вэ гэсэн асуултад хүүхдүүд дараах байдалтай хариулжээ. (хариулт хувиар)

Амьдрах ухаан–42.7, Эрүүл мэнд–39.1, Спорт–34.0, Мэргэжил–28.7, Гадаад хэл–24.5 байсан бөгөөд хамгийн бага үзүүлэлт нь хүмүүсийн харилцаа, экологийн тухай мэдээлэл байв. Үүнээс үзэхэд хот, хөдөөгийн өсвөр үеийнхэнд мэдээлэл олж авах нөхцөл эрс ялгаатай, хөдөөгийнхэнд хэрэгцээтэй зөв мэдээлэл олж авах боломж муу байна.

Монголын хүүхэд залуучуудын хөгжлийн төв олон улсын боловсролын үзэсгэлэн яармагийг тогтмол зохион байгуулж, боловсролын тухай мэдээллийг үнэн зөв, өргөн дэлгэр, нээлттэй болгохыг эрмэлзэж байна.

### **Хөдөөгийн хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг арилгах талаар**

Хөдөө орон нутгийн хүүхдийн 46.6 хувь нь ямар нэгэн арга хэмжээнд юунд ч хамрагддаггүй гэсэн байна. Ирээдүйн мэргэжлээ хэрхэн сонгох тухай асуултад нийслэл ба хот, суурин газар амьдарч байгаа хүүхдүүдийн 40 хувь нь эдийн засагч, орчуулагч, бизнесмэн, хуульч, улс төрч, дизайнер зэрэг орчин үеийн сонирхол татах мэргэжлүүдийг сонирхож байхад, хөдөө орон нутгийн хүүхдүүдийн дөнгөж 6 хувь нь энэ мэргэжлүүдийг

сонирхож байна. Мөн ямар нэгэн өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл авч чаддаггүй хүүхдийн тоо нийслэлд 45.6 хувь, хөдөө орон нутагт 63.0 хувь байна. Энэ байдалд өсвөр үеийнхэн өөрсдөө дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Хүүхэд, өсвөр үеийн төлөө үйл ажиллагаа явуулдаг нийслэлд төвлөрсөн олон улсын ба төрийн бус байгууллагын салбарыг хөдөө орон нутагт байгуулах;
- Хөдөө орон нутагт ашиглагдахгүй байгаа байшин, байгууламжийг иргэний нийгмийн байгууллагуудын мэдэлд шилжүүлэн ашиглуулах;
- Хүмүүсийг нас хүйс, оршин суугаа газар, нийгмийн байдлаар нь ялгаварлан тэгш бус ханддаг, хүсэл эрмэлзлэлийг нь боогдуулдаг хандлагыг эрс өөрчлөх;
- Зах хязгаар нутгийн хүүхдийг улсын чанартай арга хэмжээнд хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар өргөн оролцуулдаг болох;
- Хөдөөгийн хүүхэд, өсвөр үеийнхний хөгжил дэвшилд илүүтэй анхаарах бодлого, үйл ажиллагаа явуулах зэрэг.

#### **Хүүхэд, өсвөр үеийнхний сурч боловсроход гардаг бэрхшээлийн талаар**

- Судалгаанд оролцогчид сурахад гардаг бэрхшээлийг:
- Ядуурлаас улбаалан шаардагдах хэрэгцээгээ хангаж чаддаггүй
- Сургууль дээр үе тэнгийнхний элдэв дарамт шахалт их гардаг
- Багш, сурагчийн хооронд үл ойлголцох зүйл гардаг
- Хичээлүүд сонирхолгүй байдаг
- Орчин үеийн мэдээллийн хэрэгсэл байдаггүй
- Багш, сурагч бүгд сэтгэл санааны хүнд дарамттай байх зэрэг гэж дурджээ.

#### **Хүүхэд, өсвөр үеийнхний нийгмийн оролцооны талаар өсвөр үеийнхэн**

- Санал бодлоо найз нөхөд, эцэг, эх, хэвлэл радиод илэрхийлдэг – 80.0 хувь
- Насанд хүрэгчдийн туслалцаагүйгээр өөрөө шийдвэр гаргадаг – 21.9 хувь
- Хүүхдийн байгууллага хөдөлгөөнд хамрагдаагүй – 79.5 хувь
- Чөлөөт цагаа хамгийн их зарцуулдаг зүйл гэрийн ажил – 46.2 хувь
- Олон нийтийн арга хэмжээнд оролцоход бэрхшээлтэй – 37.2 хувь
- Зохиож байгаа ажил, арга хэмжээ сонирхолгүй – 16.1 хувь гэж хариулсан байна.

### **VIII хэсэг**

#### **Өмнөх илтгэлтэй холбогдсон санал, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байдал**

1. Хүүхдийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын хамтын ажиллагааны нэгдмэл байдал төдийлөн хангагдахгүй байна. Харин үндэсний хэмжээнд төрийн бус байгууллагууд төрийн байгууллагын зарим чиг үүргийг гүйцэтгэх талаар санаачилгатай ажиллаж байна. Орон нутагт төрийн бус байгууллагын салбарууд эдийн засгийн боломжоос шалтгаалан жигд бус ажиллаж байна. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтэд хяналт тавих, салбар хоорондын ажлыг

уялдуулан зохицуулах өнөөгийн тогтолцоо оновчтой бус байна.

2. Хүүхэд, ялангуяа эмзэг бүлгийн хүүхдийн холбогдолтой 13 төрлийн мэдээллийг жилийн эцэст авч үндэсний хэмжээнд нэгтгэх болсон. Үүний зэрэгцээ хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн тодорхой асуудалд судалгаа шинжилгээ хийх болсон нь хүүхдийн талаарх бодлого боловсруулахад үнэтэй мэдээлэл болж байна. Гэвч хүүхдийн талаарх мэдээллүүд нь хоорондоо зарчмын зөрүүтэй, далайц багатайн зэрэгцээ гарсан үр дүнгийн талаар нийтэд нээлттэй бус байдаг. Хүүхдийн асуудлаар мэргэжсэн хүүхдийн эрхийн өмгөөллийн (омбудсмeны) тогтолцоог нэлээд судалсны эцэст Хүний эрхийн Үндэсний Комиссыг байгуулсан бөгөөд Хүний эрхийн Үндэсний Комиссын хүрээнд хүүхдийн эрхийн чиглэлээр үр дүнтэй ажиллахыг эрмэлзэж байна.

3. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн тухай олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааны хэлбэрийг өргөн хүрээнд ашигладаг бөгөөд конвенцийг сурталчлах үндэсний болон орон нутгийн сургагчдыг тогтмол бэлтгэн мэргэшүүлж байна. Энэ ажилд олон улсын ба төрийн бус байгууллагууд идэвхтэй дэмжлэг үзүүлж байна. Хүүхдийн оролцооны эрхийг хүндэтгэх, шийдвэр гаргахдаа тэдний санал бодлыг харгалзан үзэж байхыг нийгмийн зүгээс хүлээн зөвшөөрч, дэмжиж байна.

4. Хүүхдийн эрхийн тухай сургалтад их ач холбогдол өгч жил бүрийн төлөвлөгөөний дагуу хүүхэдтэй ажилладаг хүмүүст зориулсан сургалтуудыг төрийн ба төрийн бус байгууллагууд өргөн зохион байгуулдаг. Монголын Хүүхдийн төлөө Үндэсний хороо, Монголын хүүхдийн эрхийн төвөөс Хүүхдийн эрхийг тухай конвенцийн үндэсний болон орон нутгийн сургагчийг бэлтгэх, давтан бэлтгэхэд илүү анхаарч байна. Зохион байгуулж байгаа сургалт семинар нь агуулга, арга зүйн хувьд нилээд сайжирч хэлбэрийн хувьд өргөжин оролцогчдын хэрэгцээг бүрэн хангаж байна. Харин хөдөө, орон нутаг сургалтыг үргэлжлүүлэхэд хөрөнгө төсвийн хомсдол бэрхшээл учруулж байна.

5. Хүүхэд төрөлтийн бүртгэлийг хуулийн дагуу төв, орон нутгийн засаг захиргааны байгууллагууд гүйцэтгэж байна. Иргэний бүртгэл мэдээллийн улсын төв хүүхэд төрөлтийн бүртгэлийг хангалттай хэмжээнд байгаа гэж үздэг. Гэвч шинээр төрсөн хүүхдийг бүртгүүлэхэд бага зэргийн хураамж авах бөгөөд төлбөрийн чадваргүй өрх түүнээс болж бүртгэлийн хуулийн хугацаанаас хоцрон алданги хэмээх “төлбөрт” ордог. Энэ нь хүүхдээ бүртгүүлэхээс зайлсхийхэд хүргэж байна.

6. Нийгмийн үндсэн төрлийн үйлчилгээний хүртээмжийг хөдөөгийн хийгээд тахир дутуу хүүхдүүдийн хувьд нэмэгдүүлэхэд НҮБ–ын ХС–ийн дэмжлэгээр хэрэгжүүлсэн Тахир дутуу хүүхдийг олон нийтийн хүчинд тулгуурлан нөхөн сэргээх 5 жилийн хугацаатай төсөл үр дүн өгч ялангуяа Хан–Уул, Налайх дүүрэгт нийгмийн үйлчилгээний байгууллагуудын цогц үйлчилгээг хүүхэд, гэр бүлд хүргэх загварыг бий болгов.

7. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн заалтыг үндэсний хууль тогтоомжид хэрхэн тодорхойлсон байдалд харьцуулсан судалгаа хийж түүнийг боловсронгуй болгох талаар саналын үндэслэл гаргасан. Судалгаагаар үндэсний 50 гаруй хуульд холбогдох заалт байгаа бөгөөд НҮБ–ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн нэгдүгээр бүлгийн 40 зүйлийн 65 хувь Монгол Улсын үндэсний хууль тогтоомжуудад агуулгын хувьд бүрэн туссан бөгөөд харин үлдэж буй 35 хувийг (9. 10. 13. 16. 17. 20. 21. 22. 24. 33. 35. 37. 38) эзлэх зүйлийг үндэсний хууль тогтоомжид тодорхой нэмэлт, тодотгол зэргийг оруулах замаар

агуулгыг бүрэн гаргах шаардлагатай байна.

8. Гаагийн конвенцид 1998 онд нэгдэн орж, “Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журам”-ыг Хууль зүй, дотоод хэргийн болон Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаалаар батлан хэрэгжүүлж байна.

9. Дүрвэгсдийн статусын тухай конвенцид нэгдээгүй байна.

10. Хүүхдийн төлөө үйл ажиллагаанд нөөц хүчийг гурван чиглэлээр зохион байгуулж байгаа талаар илтгэлийн танилцуулгын хэсэгт дэлгэрэнгүй дурдсан болно.

11. Хүүхдийн эрхийн зөрчлийн түгээмэл хэлбэр болсон хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд бие даасан хөтөлбөр, төсөл хэрэгжүүлээгүй. Хүчирхийллийн эсрэг үндэсний төв хэмээх төрийн бус байгууллага 1997 оноос идэвхтэй үйл ажиллагаа явуулж хүүхдийн эсрэг асуудлын мөн чанарыг ойлгуулах, таниулахад их үүрэг гүйцэтгэж байна. Энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын жижиг хөтөлбөр, төслийг уялдуулах, зохицуулах талаар дорвитой өөрчлөлт гаргаж чадсангүй.

12. Насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны онцлогийг үндэсний хууль тогтоомжид хүлээн зөвшөөрч нийцүүлдэг ч түүнийг сурталчлах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл ажиллагаа зохих түвшинд хүрээгүй байна. Үүнд иргэдийн хүүхдийн эрх зүйн боловсролын мэдлэг, чадвар, дадалын түвшин ч нөлөөлж байна.

13. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК) нь Парисын зарчим буюу хүний эрхийн үндэсний байгууллагын хэм хэмжээний дагуу Монгол Улсын Их хурлаас 2001 оны 2 дугаар сард байгуулагдсан. Монгол Улсын хууль, Монгол Улсын нэгдэж орсон олон улсын гэрээнд заасан хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавьдаг. Комисс 3 гишүүнтэй, түүний ажлын алба 9 ажилтантай бөгөөд байгуулагдсанаас хойш “Монгол Улсад хүний эрхийг хангах хөтөлбөр” боловсруулах төслийн багтай хамтарч улсын хэмжээнд хүний эрхийн судалгаа явуулж тайланг нэгтгэн хэвлүүлэх, төрийн бус байгууллагатай хамтарсан сургалт зохион байгуулах, иргэдийн өргөдөл, гомдол хүлээн авч шалгаж барагдуулах зэргээр ажиллаж байна. Хүний эрхийн салбарын олон улсын хөтөлбөр, төслийн шугамаар Монголын нээлттэй нийгмийн хүрээлэнгийн дэмжлэгтэйгээр дунд сургуулийн эрх зүйн хичээлийн агуулга, арга зүйн шинэчлэх томоохон хөтөлбөрийн хүрээнд эрх зүйн сургалтын агуулга, арга зүй, багшийн нөөц бүрэн шинэчлэгдэх боломжтой боллоо. Харин хүүхдийн эрхийн чиглэлээр үндэсний байгууллагын чадавхыг нэмэгдүүлэхэд дорвитой өөрчлөлт гарч чадсангүй. Шүүх, хууль хяналтын болон хорих байгууллагын ажилтан, нийгмийн асуудал эрхэлсэн захиргааны ажилтнуудад зориулсан богино хугацааны сургалтуудын чанар олон улсын түвшингийн шаардлагыг төдийлөн хангаж чадахгүй байна. Монголд хүний эрхийн шинэ тутам үүссэн байгууллагуудын үйл ажиллагаа идэвхжиж, олон улсын хүний эрхийн байгууллагуудын тусламж дэмжлэг нэмэгдэж байна.

14. Өнгөрсөн 10 жилд буюу 1991–2000 оны хугацаанд хандивлагчид хөгжлийн албан ёсны тусламж (ХАЁТ)-ийн (зээл, тусламж, бүх хэлбэрийн төслийн, техникийн туслалцааны санхүүгийн) хүрээнд нийтдээ 2.6 тэрбум ам.долларыг Монгол Улсад олгохоор амласан тооцоо гарч байна. Нийт амласан ХАЁТ-ийн 72 хувь буюу 1.9 тэрбум ам.долларын зээл, тусламжийг бодитойгоор ашигласан байна. Нийт ашигласан ХАЁТ-

ийн 52.4 (995,6 сая) хувийг буцалтгүй тусламж, 47,0 (904.4 сая) хувийг хөнгөлөлттэй зээл эзэлж байна.

Цаашид хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийг хөгжүүлэх, тэдэнд нийгмийн халамж, үйлчилгээ үзүүлэх, хүүхдийн байдлыг сайжруулах үйл ажиллагааны удирдлага, зохицуулалтыг оновчтой болгохоор чармайж байна.

Хүнд нөхцөлд байгаа хүүхдийн тоог нэмэгдүүлэхэд хүргэдэг хүчин зүйлийг тогтоох, урьдчилан сэргийлэхэд анхаарч, Хүүхэд өсвөр үеийнхний байдлыг сайжруулах үйл ажиллагааны хоёр дахь шатны (2010 он хүртэл) хөтөлбөрийг үндэсний онцлогт тохируулан боловсруулах, үндэсний зөвшилцөлд хүрэх замаар баталгаажуулан хэрэгжүүлнэ.

Нийгмийн халамж, хамгааллын бодлого хувь хүний дотоод хүчин зүйл, чадавхыг нэмэгдүүлэх, хөгжүүлэхэд чиглэсэн иргэний нийгмийн санаачлагыг дэмжин, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

НҮБХХ нь мэдлэг, туршлага, нөөцийг холбож улс орнуудын өөрчлөлтийг олон нийтэд хүргэх замаар илүү сайн сайхан амьдралыг цогцлон байгуулахад хүмүүст туслах зорилго бүхий НҮБ-ын дэлхий нийтийн хөгжлийн сүлжээ юм.

### **6.3 ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ХОЁР ДАХЬ ТАЙЛАН, ИЛТГЭЛИЙГ ХЭЛЭЛЦЭЭД НҮБ-ЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХОРООНООС ӨГСӨН ЗӨВЛӨМЖ**

1. Хүүхдийн Эрхийн Хороо нь Монгол Улсын хоёрдугаар илтгэлийг (CRC/C/65/Add.32) 2003 оны тавдугаар сарын 6-нд хүлээн авч, 2005 оны тавдугаар сарын 26-нд 1040–1041 дүгээр (CRC/C/SR.1040 болон 1041) хуралдаанаар хэлэлцэж, 2005 оны зургаадугаар сарын 3-ны өдрийн 1052 дугаар хурлаас дараах зөвлөмжийг гаргав:

#### **А. Оршил**

2. Тус хороо нь Монгол Улсын хоёрдугаар илтгэлийг хүлээн авсандаа талархаж байгаа ч илтгэл бичих журмыг мөрдөөгүй, хугацаа хожимдуулсанд харамсаж байна. Мөн статистикийн чухал мэдээ, тодорхой мэдээллийг бичгээр явуулж (CRC/C/Q/MNG/2) хүүхдийн асуудлын талаар тодорхой ойлголт өгч өндөр хэмжээний төлөөлөгчид товч ярилцах замаар нэмэлт мэдээлэл өгсөнд талархаж байгаагаа тэмдэглэж байна.

#### **Б. Гишүүн улсын өмнөх илтгэлийн мөрөөр авсан арга хэмжээ, олсон амжилт**

3. Хүүхдийн эрхийг хамгаалах, бэхжүүлэх чиглэлээр дараах хуулийг баталсныг Хороо сайшаан тэмдэглэж байна. Үүнд:

- а. Хүүхдийн тусгай хамгааллын хууль зүйн хүрээг хангаж өгсөн Хүүхдийн эрхийг хамгаалах тухай 1996 оны хууль;
- б. Тахир дутуу болон хууль ёсны асран хамгаалагчгүй өнчин хүүхдүүдэд хүртээх нийгмийн халамжийн хэлбэр, хамрах хүрээг тогтоож өгсөн Нийгмийн халамжийн тухай 1998 оны хууль;
- в. Хүүхдэд эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламж үзүүлэх асуудлыг тусгасан Эрүүл мэндийн тухай 1998 оны хууль;
- г. Хүүхдийн хөдөлмөр, тэдгээрийн ажиллах нөхцөлийг зохицуулсан Хөдөлмөрийн тухай 1998 оны хууль;
- д. Эцэг эхийн үүрэг, үрчлэлт, асран хамгаалал, хүүхдийн мөнгө төлөлтийн асуудлыг зохицуулсан Гэр бүлийн тухай 1999 оны хууль;
- е. Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын тухай 2000 оны хууль, түүнийг байгуулсан явдал;
- ё. Хүүхдийн үйлдсэн гэмт хэрэг, хүүхэд, гэр бүл, нийгмийн эсрэг гэмт хэргийн талаар тусгай бүлэг оруулан шинэчилж найруулсан Эрүүгийн байцаан шийтгэх тухай 2002 оны хууль;

- ж. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, хохирогчийн хүний эрх, тэр дундаа хохирогч хүүхдийг хамгаалах зорилготой баталсан Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг 2004 оны хууль.

4. Монголын хүүхдийн эрх, эрх зүйн байдалтай холбогдуулан гишүүн улс 1997 оныг Хүүхдийн жил, 1998 оныг Залуучуудын жил, 2000 оныг Хүүхдийн хөгжлийг дэмжих жил, 2001 оныг Тахир дутуу иргэдийг дэмжих жил болгон зарлаж, 2004 оноос Хүүхдийн үндэсний чуулганыг зохион байгуулах талаар чармайлт гарган анхаарч байгаад Хороо талархаж байна. Оролцогч улсаас хүүхдийн нийгмийн үйлчилгээнд зориулсан төсвийг нэмэгдүүлэх талаар гаргаж байгаа хүчин чармайлтыг Хорооноос мөн үнэлэн тэмдэглэж байна.

5. Хороо дараах олон улсын гэрээг соёрхон баталсанд мөн талархаж байна:
- а. 2000 оны дөрөвдүгээр сард Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай Гаагийн 33 дугаар Конвенц;
  - б. 2001 оны хоёрдугаар сард Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг нэн даруй устгах, хориглох тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 182 дугаар Конвенц;
  - в. 2002 оны нэгдүгээр сард Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц;
  - г. 2002 оны гуравдугаар сард Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн нэмэлт протокол;
  - д. 2002 оны 12 дугаар сард Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 138 дугаар конвенц;
  - е. 2003 оны зургаадугаар сард Хүүхдийн Эрхийн тухай Конвенцийн Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг нэмэлт протокол;
  - ё. 2004 оны 10 дугаар сард Хүүхдийн эрхийн конвенцийн Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг нэмэлт протокол.

#### **В. Конвенцийг хэрэгжүүлэхэд саад болж буй бэрхшээл, хүчин зүйл**

6. Монгол Улсад 1991 оноос эхэлсэн эдийн засгийн шилжилт харьцангуй хурдан явагдаж, нийгэмд гүн гүнзгий нөлөө үзүүлснийг Хороо тэмдэглэж байна. Эдийн засгийн тогтворгүй байдал, ажилгүйдэл, өсөн нэмэгдэж байгаа ядуурал нь олон хүүхэдтэй болон хөдөө орон нутагт амьдарч буй гэр бүлд нөлөөлж байна. Гишүүн улс нь дэлхийн хамгийн бага хүн амтай, өргөн уудам нутагтай онцлогийг харгалзаж буйгаа Хороо тэмдэглэж байна. Түүнчлэн 1999–2001 онд жил дараалан тохиосон ган, зуд эрэг байгалийн онц хүнд нөхцөл нь нийгэм, эдийн засгийн хүндрэлийг эрс нэмэгдүүлж, олон мянган хүүхэд, нэн ялангуяа хол нутгийн хүүхдийн амьдралд муугаар нөлөөлж, тус улсын нийт хөгжилд сөрөг нөлөө үзүүлснийг Хороо хүлээн зөвшөөрч байна.



## **Г. Холбогдох зарчмын асуудал болон зөвлөмж**

### **1. Хэрэгжүүлэх ерөнхий арга хэмжээ (Конвенцийн 4, 42, 44 дүгээр зүйл, 6 дугаар бүлэг)**

#### **Хорооны өмнөх зөвлөмж:**

7. Гишүүн улсын анхны тайлантай холбоотой Хорооны зөвлөмжийг (CRC/C/15/Add.99) хэрэгжүүлэх талаар хууль тогтоомж, бодлогын хүрээнд хийсэн өөрчлөлтүүдэд Хороо сэтгэл ханамжтай байсныг тэмдэглэж байна. Гэвч аймаг, орон нутгийн эрэгтэй хүүхдийн сургууль завсардалт, хүүхдийн хөдөлмөрт татагдан орж байгаа байдал (23 дугаар зүйл), орон нутгийн хүүхдэд зориулсан хамгаалал, боловсрол, эрүүл мэнд, нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх нийгмийн суурь үйлчилгээг бэхжүүлэх (23 дугаар зүйл), дүрвэгч хүүхдийн эрхийг хангаж хамгаалах (26 дугаар зүйл), хөрөнгө нөөцийг төв болон орон нутагт зохистой хуваарилах (27 дугаар зүйл), хууль зөрчсөн хүүхдийн эрх (29 дүгээр зүйл) зэргийг бүрэн шийдвэрлэж чадаагүй байна.

8. Гишүүн улсын анхны илтгэлд Хорооноос өгсөн нэн даруй анхаарах асуудал, түүнийг шийдэх зөвлөмжөөс хэрэгжүүлээгүй байгаа зүйл болон хоёрдугаар илтгэлтэй холбогдсон зөвлөмжийг биелүүлэхэд анхаарал тавьж ажиллахыг Хороо шаардаж байна.

#### **Хууль тогтоомж**

9. Хүүхдийн эрхийг хамгаалж, бэхжүүлэх чиглэлээр хууль эрх зүйн шинэтгэл хийсэнд талархаж байна. Хэдийгээр дотоодын хууль тогтоомжоо сайжруулсан ч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ хангалтгүй, хууль нь амьдралаас хол байх хандлагатай байна. Нэмж дурдахад зарим заалт хүүхдийн эрхийг хангалттай хамгаалж чадахгүй, хоорондоо зөрчилтэй байгаад санаа зовж байна. Тухайлбал 14–15 настай хүүхэд долоо хоногт 30 цаг ажиллаж болохыг Хөдөлмөрийн тухай хуулиар зөвшөөрсөн нь хүүхэд бүр заавал боловсрол эзэмших заалттай зөрчилдөж байгаа юм.

10. Шинээр батлагдсан төдийгүй нийт хууль тогтоомжоо үр дүнтэй хэрэгжүүлэхэд санхүү, хүний нөөцийг зохистой хуваарилах зэргээр шаардлагатай бүх арга хэмжээ авч ажиллахыг зөвлөж байна. Мөн хүүхдийг хамгаалахад гарч болзошгүй хийдлээс сэргийлэхийн тулд дотоодын хууль тогтоомжоо хянан үзэхийг зөвлөж байна.

#### **Зохицуулалт болон Үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр**

11. Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах Үндэсний хөтөлбөрийг 1990–2000 онд хэрэгжүүлж тодорхой үр дүнд хүрснийг талархан тэмдэглэж байна. Түүнчлэн хоёр дахь шатны хөтөлбөрийг 2002–2010 онд хэрэгжүүлэхээр баталсан, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн A/RES/S-27/2 тогтоолоор баталсан НҮБ-ын Хүүхдийн асуудлаарх Тусгай Чуулганы “Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц” баримт бичгийн үзэл санааг биелүүлэх талаар санаачилгатай ажиллаж байгааг сайшааж байна. 2004 оны есдүгээр сард батлагдсан Хүүхдийн төлөө Үндэсний Газрын стратеги, бүтцийг сайшааж байгаа ч салбар хоорондын зохицуулалтыг сайжруулах стратегийн нарийн төлөвлөгөө байхгүй, бүх шатны байгууллагад Хүүхдийн төлөө Үндэсний Газрын шинэ чиг үүргийг ойлгуулах сургалт

дутагдалтай байгаад сэтгэл зовниж буйгаа илэрхийлье.

12. 2002–2010 онд хэрэгжих Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах хоёр дахь шатны үндэсний хөтөлбөрийг бүрэн, үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хөрөнгө санхүү, техник, хүний нөөцөөр бүрэн хангах, мөн хөтөлбөрийн хэрэгжилтийн үйл явц нь хүний эрхийн зарчимд суурилсан, нээлттэй, оролцоог хангахыг онцгойлон зөвлөж байна. Түүнчлэн конвенцийг хэрэгжүүлэхэд оролцох бүх шатны үйл ажиллагааны зохицуулалтыг хангах стратегийн иж бүрэн төлөвлөгөө боловсруулах, Хүүхдийн төлөө үндэсний газрын шинэ чиг үүргийг дэмжих, сургалт мэдээллээр хангах, салбар хоорондын уялдаа холбоог зохицуулах үйл ажиллагааг хэрхэн гүйцэтгэсэн талаар Хүүхдийн төлөө үндэсний газар дараагийн илтгэлдээ тусгахыг зөвлөж байна.

### **Бие даасан хяналт**

13. Хүний Эрхийн Үндэсний Комиссыг 2001 онд байгуулж, үндэсний гурван комиссарын нэгийг хүүхдийн эрхийн мандатай болгон, цаашид хүүхдийн эрхийн асуудлаар дагнан ажиллах омбудсменийг бий болгох талаар анхаарч байгаад Хороо талархал дэвшүүлж байна.

14. Хүний эрхийг хамгаалах үндэсний бие даасан байгууллагын үүргийн талаарх ерөнхий зөвлөмжийн хоёр дугаарт заасны дагуу Хүний Эрхийн Үндэсний Комиссыг санхүү, техник, хүний нөөцөөр бүрэн хангах, тус комисс Хүүхдийн эрхийн конвенцийн хэрэгжилтийг үндэсний болон орон нутгийн түвшинд хянах, үнэлэх, хүүхдийн гомдлыг хүлээн авах, судлах, шийдвэрлэх боломжийг бүрдүүлэхийг зөвлөж байна. Хүүхдийн тусгай омбудсментэй болох асуудлыг хэлэлцэж буй явцыг шуурхайлахыг санал болгож байна. Түүнчлэн авлигатай тэмцэх, сайн засаглалын стратегийг хөгжүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авахыг зөвлөж байна.

### **Нөөцийн хуваарилалт**

15. Оролцогч улс 20:20 санхүүжилтийн санаачилгыг хэрэгжүүлэх замаар хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээ, хүүхдийн сайн сайхны төлөө дотоодын нөөцөө дайчлахыг эрхэмлэж байгааг дэмжиж байна. Гэвч хүүхдэд зарцуулж байгаа санхүүжилтийн хэмжээ нь үндэсний болон орон нутгийн түвшинд хүүхдийн эрхийг хамгаалах, сайжруулах хэрэгцээг хангаж чадахгүй байгаад Хороо харамсаж байна. Хүүхдэд үзүүлж байгаа үйлчилгээний хувьд хот, хөдөөгийн ялгаа их байгаад сэтгэл зовниж байна.

16. Хороо Оролцогч улсад дараах зөвлөмжийг өгч байна.

- a. Хүүхдийн эрхийг хэрэгжүүлэхэд зарцуулж байгаа төсвийн хувийг нэмэгдүүлэх, хүний нөөцөөр хангах, хот хөдөөгийн хүүхдүүд эрхээ эдлэхэд гарч байгаа ялгаатай байдлыг арилгах, алслагдсан нутаг болон сум суурины хүүхдийг онцгойлон анхаарах, хүүхдэд зориулсан бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх асуудлыг эн тэргүүнд тавих;
- б. Олон улсын санхүүгийн болон НҮБ-ын төрөлжсөн байгууллага болон хоёр талын хамтын ажиллагааны хандивлагчтай хамтран ажиллах явдлыг үргэлжлүүлэх.

### **Мэдээ цуглуулах**

17. Тус улсын статистикийн тогтолцоонд эдийн засгийн шилжилтийн үе ихээхэн өөрчлөлт хийхэд хүргэсэн гэдгийг Хороо хүлээн зөвшөөрч байна. 2002–2010 онд хэрэгжүүлэх Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийг боловсруулахдаа үндэслэсэн “Хүүхэд хөгжил–2000” судалгаа зэрэг статистикийн мэдээ цуглуулахад гаргасан хичээл зүтгэлийг сайшаан тэмдэглэж байна. Гэвч мэдээ баримт цуглуулалт боловсронгуй бус, конвенцийн зүйл заалт бүрийг хамарч чадахгүй байгаад сэтгэл зовниж буйгаа илэрхийлье.

18. Хороо Оролцогч улсад дараах зөвлөмжийг өгч байна:

- а. 18 нас хүртэлх бүх хүүхдийг хамарсан үндэсний хэмжээний статистик мэдээг системтэй цуглуулах тогтолцоо бүрдүүлэх, ялангуяа тахир дутуу, нэн ядуу нөхцөлд амьдарч буй, хөдөө амьдарч буй, шилжин суурьшсан, хүчирхийлэлд өртсөн, хараа хяналтгүй, хууль зөрчсөн, үндэстний цөөнхийн хүүхэд гэх мэт эмзэг нөхцөлд байгаа хүүхдийн талаар мэдээг системтэй цуглуулах;
- б. Конвенцийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөр, бодлогыг боловсруулах, хянах, үнэлэхэд дээрх мэдээ, үзүүлэлтүүдийг ашиглах;
- в. Дээрх статистикийн мэдээг хэвлүүлэх шинэлэг арга замыг хайх, мэдээг нийтэд нээлттэй болгох;
- г. Энэ талаар НҮБ–ын Хүүхдийн Сан болон бусад байгууллагатай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэх.

### **Конвенцийг түгээх**

19. Конвенцийн агуулга, зарчмыг хүүхдийн асуудлаар сэдэвчилсэн жилийн ажлууд, 1998, 2001 онд хуралдсан Монголын Хүүхдийн үндэсний чуулган, сургалтуудаар дамжуулан сурталчилж байсныг сайшааж байгаа ч нийгмийн бүхий л давхарга, бүс нутагт хүргэх талаар учир дутагдалтай, хөдөө орон нутаг, үндэстний цөөнхийн хэмжээнд сурталчлах ажил хангалтгүй байснаас уг ажил хүссэн үр дүнд хүрээгүйд сэтгэл дундуур буйгаа илэрхийлж байна.

20. Хүүхдийн төлөө ажилладаг мэргэжилтнийг сургах, давтан сургах ажлыг төрийн бус байгууллага болон олон улсын байгууллагатай хамтран явуулж байгааг тэмдэглэж байна. Гэвч эдгээр арга хэмжээг цаашид бэхжүүлж, иж бүрэн системтэй, тасралтгүй байдлаар хэрэгжүүлэхэд анхаарах хэрэгтэй гэж үзэж байна.

21. Хороо Оролцогч улсад дараах зөвлөмжийг өгч байна:

- а. Конвенцийг түгээхэд ялангуяа орон нутгийн түвшинд болон үндэсний цөөнхийн хэмжээнд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, хүүхдэд ээлтэй, бүтээлч арга хэлбэрийг хөгжүүлэх;
- б. Сургуулийн сургалтын хөтөлбөрт Конвенцийн заалт, зарчмыг тусгах;
- в. Шүүгч, хуульч, хууль хэрэгжүүлэх болон эрүүл мэндийн салбарын ажилтан, багш, сургууль, асрамжийн газрын удирдлага, нийгмийн ажилтан, сэтгүүлч зэрэг хүүхдийн төлөө, хүүхэдтэй ажилладаг мэргэжлийн бүлгүүдийг хүүхдийн эрхийн тухай ойлголттой болгох, сургалтад системтэй хамруулах талаар хүч чармайлт гаргах;

- г. НҮБ–ын Хүүхдийн Сан(НҮБХС), НҮБ–ын Хүний эрхийн дээд комиссын газар(ХЭДКГ), НҮБ–ын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Байгууллага (ЮНЕСКО) зэргээс техникийн тусламж авахаа үргэлжлүүлэх.

## **2. Үндсэн зарчим (Конвенцийн 2, 3, 6, 12 дугаар зүйл)**

### **Ялгаварлан гадуурхахгүй байх**

22. 1992 оны Үндсэн хууль, 1996 оны Хүүхдийн эрхийг хамгаалах хуулиар хүүхэд бүхэн тэгш эрхтэй байхыг хуульчилж, конвенцийн ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг тусгасан явдалд Хороо талархаж байна. Гэвч хөгжлийн бэрхшээлтэй, ядуу, хууль зөрчсөн, хараа хяналтгүй, хөдөө орон нутагт амьдарч байгаа, нийслэлд шилжин суурьшсан хүүхэд албан ёсны бүртгэлгүйгээс болоод эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ хүртэж чадахгүй, сургуулийн хүртээмж тааруугаас хүүхдүүд ялгаварлан гадуурхагдаж байгаад Хороо сэтгэл зовниж байна.

23. Конвенцийн 2 дугаар зүйлд заасны дагуу хүүхэд бүр Хүүхдийн эрхийн конвенцэд заасан бүх эрхээ аливаа ялгаварлалгүйгээр ижил тэгш эдлэх боломжийг одоо мөрдөж байгаа хуулийн хүрээнд баталгаажуулснаа бодитой хэрэгжүүлэхийг бүрэн эрхийнхээ хүрээнд бүх боломжоо дайчлан ажиллахыг хүсэж байна. Эмзэг бүлгийн хүүхдүүдийн эсрэг болон хүүхдийн эсрэг бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх, арилгахын тулд иж бүрэн, үр дүнтэй стратегийг боловсруулан хэрэгжүүлэх, нийгмийн эмзэг бүлгийн хүүхдэд эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээг эн тэргүүнд хүргэх, тэднийг боловсрол эзэмших тэгш боломжоор хангахыг зөвлөж байна.

24. Боловсролын зорилтын тухай 2001 оны Хорооны ерөнхий саналын №1–д заасны дагуу болон арьсны үзэл, арьс өнгө, үндэс угсаагаар ялгаварлан гадуурхах аливаа үзэлтэй тэмцэх талаар 2001 оны Дэлхийн бага хурлаар батлагдсан тунхаглал, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Хүүхдийн эрхийн конвенцийн хүрээнд хэрэгжүүлж буй хөтөлбөр, арга хэмжээнийхээ тухай онцгой мэдээллийг дараагийн илтгэлдээ оруулахыг зөвлөж байна.

### **Хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх талаар**

25. Монголын өсвөр үеийнхний эрхийг хамгаалахын тулд 1998, 1999 оны НҮБ–ын “Нэг ертөнц” цуврал бага хурал, мини Засгийн газар, мини Парламентын хуралдаан, 1998, 2001 оны Монголын Хүүхдийн үндэсний чуулган, 2004 оны Хүүхдийн төлөө үндэсний чуулга уулзалтыг зохион байгуулах зэргээр өөрсдийн эрх ашигтай холбоотой бүхий л асуудлаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, нийгмийн амьдралд оролцох хүүхдийн эрхийг хүндэтгэх, дээшлүүлэх талаар явуулсан үйл ажиллагааг сайшаан тэмдэглэж байна. Гэвч уламжлалт хандлагаас болоод гэр бүл, сургууль, орон нутгийн хэмжээнд хүүхэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь хязгаарлагдаж байгаад зовниж байна.

26. Конвенцийн 12 дугаар зүйлийн дагуу бүх хүүхдийн, нэн ялангуяа охидын санаа бодлыг хүндэтгэх, сургууль, гэр бүл болон бусад байгууллагын өөртэй нь холбоотой бүхий л асуудалд хүүхдийн оролцоог дэмжих чиглэлээрх ажлаа улам бэхжүүлэхийг зөвлөж

байна. Мөн бодлого боловсруулах, шүүхийн шийдвэр гаргах, хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэгт хүүхдийн үзэл бодлыг хэрхэн анхаарч байгаа, энэ нь дээрх үйл явц болон хүүхдүүдэд ямар үр нөлөөтэй байгааг байнга үнэлж үзэж байхыг зөвлөж байна.

### **3. Иргэний эрх, эрх чөлөө (Конвенцийн 7, 8, 13–17, 19, 37(а) заалт)**

#### **Төрсний бүртгэл**

27. Хүүхдийн төрөнгүүтээ бүртгүүлэх эрхийн хэрэгжилт хангалтгүй байгаад зовниж буйгаа дахин илэрхийлье. Шинээр төрсөн хүүхдийг бүртгэхэд төлбөр авч байгаа нь ядуу гэр бүлд санхүүгийн бэрхшээл үүсгэж, хүүхдээ бүртгүүлэхийг хойш тавихад хүргэж байгаад зогсохгүй бүртгэл хойшлуулсанд нь нэмэлт төлбөр авдагт сэтгэл зовниж байна.

28. Бүх шатанд төрсний бүртгэлийг үнэ төлбөргүй, үр дүнтэй явуулах тогтолцоог бий болгох, төрсний бүртгэл хийх явуулын хэсэг байгуулах, алслагдсан бүс нутагт сурталчилгааны ажил өрнүүлэхийг зөвлөж байна.

#### **Зодож шийтгэх**

29. Хүүхдийг зодож шийтгэх явдал Монголын нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн хэвээр байгаа бөгөөд энэ нь гэр бүлд төдийгүй албан ёсоор хориглосон сургууль болон бусад байгууллагад гарсаар байгаад сэтгэл зовниж байна. Цаашлаад хууль тогтоомжоор гэр бүлийн хүрээнд хүүхдийг зодож шийтгэхийг хориглох талаар заалт үгүйд харамсаж байгаагаа тэмдэглэж байна.

30. Гэр бүл, сургууль болон бусад байгууллагад хүүхдийг зодож шийтгэх явдлаас сэргийлэх, тэмцэх, мөн гэр бүлийн хүрээнд хүүхдийг зодож шийтгэхийг хуулиар бүрэн хориглохыг Хороо оролцогч улсаас шаардаж байна. Мөн хүч хэрэглэхгүйгээр хүүхдийг сахилгатай байлгах бусад аргуудыг хэрэглэхийг хүүхдийн оролцоотойгоор олон нийтэд ойлгуулах, боловсрол олгоход анхаарч энэ чиглэлээр төрийн бус байгууллагуудтай нягт хамтран ажиллахыг санал болгож байна.

### **4. Гэр бүлийн орчин ба хүүхдийг халамжлах бусад хэлбэр (Конвенцийн 5, 18 (1–2 дугаар бүлэг), 9–11, 19–21, 25, 27 (4 дүгээр бүлэг) болон 39 дүгээр зүйл)**

#### **Эцэг эхийн хариуцлага**

31. Ганц бие эцэг/эхтэй гэр бүлийн тоо өсөж, тэдэнд учирч байгаа нийгэм эдийн засгийн бэрхшээл нэмэгдэж байгаад болон эрчүүдийн эцэг байх үүргийн талаар ойлголт хязгаарлагдмал байдагт Хороо санаа зовниж байна.

32. Гэр бүл, эцэг эхэд зайлшгүй шаардлагатай санхүүгийн болон бусад тусламж үзүүлэх бололцоотой бүх арга хэмжээг авах, ялангуяа хүнд нөхцөлд амьдарч байгаа ганц бие эцэг, эхтэй гэр бүлд онцгой анхаарал хандуулахыг зөвлөж байна. 2001 онд батлагдсан Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг устгах хорооны шийдвэрийг(А/56/38, 269–270 хэсэг) үндэслэн, хүүхдийг өсгөх, хөгжүүлэхэд эцэг

эх хоёулаа үүрэгтэй байх зарчмыг харгалзан, эцэг эх хоёрын хамтын хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн хууль, бодлого, боловсролын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

### **Гэр бүлийн орчноос хөндийрсөн хүүхэд**

33. Гэрээсээ дайжсаны улмаас Хүүхдийн халамжийн төвд байгаа болон асрамжийн газар байгаа хүүхдийн тоо нэмэгдсээр байгаад Хороо санаа зовниж байна. Гэр бүлийн хуулийн 9 дүгээр зүйлийн 25 дахь заалтыг харгалзан хүүхдийг /гэр бүлээс өөр орчинд/ байршуулахтай холбоотой журмууд нь Конвенцийн агуулга, зарчимтай бүрэн нийцэхгүй байна гэж Хороо үзэж байна.

34. Конвенцийн 20 дугаар зүйлийн дагуу дараах зөвлөмжийг өгч байна:

- а. Хүүхдийг гэр бүлийн орчноос тусгаарлахгүйн тулд урьдчилан сэргийлэх яаралтай арга хэмжээ авах, асрамжийн газарт байгаа хүүхдийн тоог буруулах;
- б. Асрамжийн газарт хүүхдийг байршуулахын өмнө холбогдох мэргэжлийн хүмүүс, эрх бүхий байгууллагуудын оролцоотойгоор нөхцөл байдлыг үнэлэх, шаардлагатай тохиолдолд аль болох цөөн хоногоор, мэргэжлийн байгууллагын шийдвэрээр байршуулах, конвенцийн 25 дугаар зүйлийн дагуу эргэж үнэлэх;
- в. Конвенцэд заасан эрхүүд, ялангуяа хүүхдийн язгуур эрх ашиг, гэр бүлд түшиглэсэн халамжийн бусад хэлбэрт онцгой анхаарал хандуулах замаар хүүхдийг өргөж асардаг уламжлалт тогтолцоог хөгжүүлэх;
- г. Эцэг эхэд зориулсан сургалт, зөвлөгөө, олон нийтэд түшиглэсэн хөтөлбөрөөр дамжуулан эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч нараас хүүхдээ өсгөж хүмүүжүүлэх үүргээ хэрэгжүүлэхэд нь зохих тусламж дэмжлэг үзүүлэх.

### **Үрчлэлт**

35. 1999 оны Гэр бүлийн хуулийн үрчлэлттэй холбоотой заалт, 2000 онд соёрхон баталсан “Хүүхдийг улс хооронд үрчлүүлэх асуудлаар хамтран ажиллах, хүүхдийг хамгаалах тухай Гаагийн Конвенц”, “Монгол хүүхдийг гадаадын хүнд үрчлүүлэх тухай журам”-ыг хэрэгжүүлж, дотоод, гадаад үрчлэлтийг зохицуулахад бүх боломжоороо ажиллаж байгаад талархаж байна. Хүүхдийг үрчлэх, хуурай эцэг эх нь өсгөх Монголын эртний уламжлалтай болон улс хоорондын үрчлэлт харьцангуй цөөн байдгийг тэмдэглэж байна. Гэхдээ тус улсад одоо мөрдөж байгаа хүүхэд үрчлүүлэх талаарх хууль тогтоомж нь Конвенцийн зарчимд бүрэн нийцэхгүй байгаад сэтгэл зовниж байна.

36. Холбогдох мэргэжлийн, мэргэжсэн, чадварлаг, мэргэжилтнүүдийн баг ажиллуулах замаар хүүхэд үрчлүүлэх, асруулах ажиллагааг конвенцийн зарчимтай бүрэн нийцүүлэн шийдэж байхыг зөвлөж байна.

### **Хүүхэдтэй зүй бусаар харьцах, шоовдорлох, хүчирхийлэх**

37. Оролцогч улс нь хэдийгээр хүүхэдтэй зүй бусаар харьцах, хүчирхийллийн сөрөг үр дагавар, уршгийг ойлгож, түүнээс сэргийлэх талаар арга хэмжээ авч байгаа ч дээрх асуудал байсаар байгаад сэтгэл зовниж байна. Ялангуяа ураг төрлийн хүчирхийллээс хамгаалах хууль зүйн орчин байхгүй байгаад сэтгэл зовниж байна.

38. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл болон (CRC/C/100), “Гэр бүл, сургуулийн хүрээнд хүүхдийг хүчирхийллээс хамгаалах тухай” (CRC/C/111) Хорооны ерөнхий хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжтэй уялдуулан дараах зөвлөмж өгч байна.

- а. Гэр бүлийн орчинд биеийн болоод сэтгэл санааны бүх хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх, 2004 оны тав дугаар сард батлагдсан “Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг” хуулийг хэрэгжүүлэх, хүүхдийг бүх төрлийн хүчирхийллээс бүрэн хамгаалах талаар бололцоотой бүхий л арга хэмжээг авах;
- б. Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийн хэмжээг бууруулахын тулд хүүхдийн эсрэг хүчирхийллийн учир шалтгаан, хүрээг судлах;
- в. Хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд өртөх асуудлыг бүрэн устгах, үүний тулд ураг төрлийн хүмүүс бэлгийн харьцаанд орохоос хамгаалах тухай хууль зүйн орчин бүрдүүлэх, хүчирхийллийн тохиолдлыг мэдээлэх хүүхэд болон насанд хүрэгчдэд зориулсан механизмыг бий болгох, үнэ төлбөргүй, гурван оронтой дугаар бүхий 24–цагийн тусламжийн утасны үйлчилгээг бүрэн дэмжих, хүчирхийллийн тохиолдлуудыг тууштай мөрдөн байцаах буруутай этгээдэд шүүхээр хариуцлага хүлээлгэх;
- г. Хүчирхийлэлд өртсөн хүмүүс, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүд хүчирхийлэлд өртсөн тухай мэдээлэл өгөхийг дэмждэггүй нийтийн уламжлалт хандлагыг өөрчлөх, гэр бүлийн хүчирхийллийн талаар олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв гэх мэт энэ чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх;
- д. Гэр бүлийн хүчирхийлэл болон бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой хэргийг мөрдөх, байцаан шийтгэх, хүчирхийлэгчид ял ноогдуулах хууль эрх зүйн үйл ажиллагаа нь хүүхдэд мэдрэмжтэй, хүүхдийн язгуур эрх ашгийг нэн тэргүүнд харгалздаг байх нөхцөлийг бүрдүүлэх;
- е. Хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхэд болон хүчирхийлэл үйлдсэн хүмүүст сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэргээн засал хийх, хэвийн байдалдаа буцаж дасан зохицоход нь туслах үйлчилгээ үзүүлэх хүүхдийн сэтгэл зүйч, сэтгэцийн эмгэг судлаач, нийгмийн ажилтан болон бусад нарийн мэргэжлийн хүмүүс дутагдалтай байгаа асуудлыг шийдэх.

### **Хүүхэд асрах үйлчилгээ**

39. Хүүхэд асрах үйлчилгээ, цэцэрлэгийн тоо цөөн, бүс нутгийн хувьд ихээхэн ялгаатай байгаад Хороо сэтгэл зовниж байна.

40. Конвенцийн 3 дахь бүлгийн 18 дугаар зүйлийн дагуу Хүүхэд асрах газар, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх арга хэмжээг яаралтай авах, ялангуяа энэ талаар бүс нутгийн ялгаатай байдлыг арилгахад анхаарахыг зөвлөж байна.

**5. Эрүүл мэнд, халамжийн суурь үйлчилгээ  
(Конвенцийн 3 дугаар зүйлийн 6, 18 дугаар зүйл,  
1–3 дугаар зүйлийн 23, 24, 26, 27 дугаар зүйл)**

**Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд**

41. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд маш их эмзэглэж байгаа бөгөөд тэднийг ялгаварлан гадуурхах явдал байсаар байгаад харамсаж байна. Тэдэнд зориулсан үйлчилгээний ихэнх нь төв суурин газар төвлөрснөөс хөдөө орон нутагт амьдарч байгаа тахир дутуу хүүхэд нийгэм, эдийн засгийн хүндрэл бэрхшээлд илүү өртөж байгаад сэтгэл зовниж байна. Тахир дутуу хүмүүсийн эрхийг зохицуулах хууль, “Тахир дутуу хүмүүсийн аж амьдралыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийг 1999 онд баталсан зэргийг сайшаан тэмдэглэж байгаа ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд чиглэсэн үр дүнтэй бодлого, суурь үйлчилгээ, зохицуулалт байхгүй байгаад харамсаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнд зохицсон орчин бүрдүүлэх талаар хууль тогтоомж байхгүй байсаар байна. Ийм олон хүүхэд боловсролын болон, нийгэм, эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжгүй байгааг онцлон тэмдэглэж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх статистикийн тоо баримт хангалтгүй, нийгэмд хэвшсэн буруу ойлголт, ялгаварлан гадуурхах явдал байсаар байгаад санаа зовниж байна.

42. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох тухай дүрэм (Ерөнхий Ассамблейн 48/96 тоот тогтоол) болон Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн талаар Хорооны ерөнхий хэлэлцүүлгээс(CRC/C/69) гарсан зөвлөмжтэй уялдуулан дараах асуудлыг яаралтай анхааралдаа авахыг зөвлөж байна.

- a. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд чиглэсэн үндэсний хэмжээний иж бүрэн бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн болон хүний нөөцийг хуваарилах;
- б. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар статистикийн бүрэн, задаргаатай тоо баримтыг цуглуулах, тэдгээрийг тахир дутуу хүүхэд нийгэмд тэгш боломж эдлэх эрхийг нь хангах бодлого хөтөлбөр боловсруулахад ашиглах, ялангуяа хөдөө амьдарч байгаа ийм хүүхдэд илүү анхаарсан байх;
- в. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрээс урьдчилан сэргийлэх, ялгаварлан гадуурхах үзэгдлийг бүрэн устгаж, тийм хүүхдийг нийгмийн амьдралын бүхий л хүрээнд бүрэн оролцох тэгш боломж олгох;
- г. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг аль болохоор ердийн сургуульд суралцуулах талаар бололцоотой бүх арга хэмжээг авах, зайлшгүй шаардлагатай тохиолдолд тусгай хэрэгцээнд нь нийцсэн боловсролын хөтөлбөрийг бий болгох;
- д. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай хэрэгцээнд нийцсэн орчин, мэдээлэл, харилцааг бий болгох арга хэмжээ авах;
- е. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тухай Монголын нийгэмд байгаа урхаг буруу ойлголтыг өөрчлөхийн тулд ийм хүүхдийн эрх, тусгай хэрэгцээ, мөн чадвар, боломжийн тухай ойлголтыг дээшлүүлэх.



**Эрүүл мэнд, эрүүл мэндийн үйлчилгээ**

43. Эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээг сайжруулах, ялангуяа 1993–2000 онд Дархлаажуулалтын үндэсний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлснээр улаан бурхан, менингит, сахуу зэрэг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар Оролцогч улсын хийсэн ажлыг үнэлэхийн зэрэгцээ хүүхдийн хоол тэжээлийн доройтол их байгаа, эхийн болон 5 хүртэл насны хүүхдийн эндэгдлийн түвшин өндөр, тухайлбал бүс нутгаар ялгаатай, мөн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж бүс нутагт өөр өөр байгаад сэтгэл зовниж байна. Хөхөөр дагнан хооллох түвшин буурч байгаа болон тус улс нь “Эхийн сүүг орлох бүтээгдэхүүний борлуулалтын олон улсын хэм хэмжээ” –г соёрхон батлаагүй байгаад Хороо сэтгэл зовниж байна. Эмийн хэрэглээ, түүний нөлөөний тухай мэдлэг муутай, үнэ хямд хүүхдэд зориулсан эм, эмийн бүтээгдэхүүн ховор байгаа нь ноцтой асуудлыг бий болгож байна. Ариун цэврийн нөхцөл муу, байгалийн бохирдол нэмэгдэж, цэвэр найдвартай ундны усны хүртээмж дутагдалтай байгаад сэтгэл эмзэглэж байна. Цаашилбал, хөдөөнөөс нийслэлд шилжин суурьшсан албан ёсны бүртгэлгүй хүүхэд эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээнд хамрагдах нь маш бага байгаад санаа зовж байна.

44. Дараах арга хэмжээ даруй авахыг онцлон зөвлөж байна.

- а. Оролцогч улсын бүх бүс нутгийн хүүхэд тэр дундаа алслагдсан хөдөө орон нутагт байгаа хүүхдэд эрүүл мэндийн чанартай үйлчилгээг тэгш хүргэхийн тулд тус салбарт санхүүгийн болон хүний нөөцийг хуваарилахыг чухалчлах;
- б. Төрөхийн өмнөх үйлчилгээг сайжруулж эхийн болон 5 хүртэл насны хүүхдийн эндэгдлийн түвшнийг тууштай бууруулах, ялангуяа хөдөөгийн эхчүүд, хүүхдүүдэд илүү анхаарах;
- в. Эхийн сүүг орлох бүтээгдэхүүний борлуулалтын олон улсын хэм хэмжээг батлах, хүүхдийг зургаан сар хүртэл нь хөхөөр хооллох, түүнээс хойш нярай хүүхдэд тохирсон нэмэгдэл хоолтой хослуулах;
- г. Сургуулийн сурагчдыг хооллох хөтөлбөрөөр дамжуулан хүүхдийн хоол тэжээлийн байдлыг сайжруулах, ялангуяа хөдөөгийн хүүхдэд илүү анхаарах;
- д. Хүүхдийг эмчлэх, урьдчилан сэргийлэх зориулалтын найдвартай, хямд эм, эмийн бүтээгдэхүүнээр тэгш хангах, эмийн нөлөө, хэрэглээний тухай ойлголтыг дээшлүүлэх;
- е. Цэвэр, аюулгүй ундны усны хүртээмж, ариун цэврийн байдлыг сайжруулах, хүүхдийг байгалийн бохирдлын сөрөг нөлөөллөөс хамгаалах;
- ё. Хөдөөгөөс нийслэлд шилжин суурьшсан, албан ёсны бүртгэлгүй хүүхдийн эрүүл мэндийн байдалд анхаарч, тэдэнд эрүүл мэнд нийгмийн үйлчилгээг тэгш хүртээх боломжийг бүрдүүлэх.

**Өсвөр үеийнхний эрүүл мэнд**

45. Оролцогч улс “Сурагч, өсвөр үеийнхний эрүүл мэнд нөхөн үржихүйн үндэсний хөтөлбөр”, “Эрүүл мэндийг дэмжигч сургууль” аяны хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээгээр дамжуулан өсвөр үеийнхний эрүүл мэнд болон эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлсэн явдлыг Хороо тэмдэглэж байна. Гэвч сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээ

хомс, сурагчид эрүүл мэндийн үзлэгт тогтмол орох боломж бага, сурагчдын эрүүл мэндийн талаар статистикийн тоо баримт байхгүйд сэтгэл зовниж байна. Түүнчлэн, тамхи татах, архи, мансууруулах бодис хэрэглэх амьдралын хэв маяг, халдварт бус өвчний тухайд бага анхаарч байгаад Хороо санаа зовж байна.

46. Хүүхдийн Эрхийн конвенцийн хүрээнд өсвөр үеийн эрүүл мэндийн талаар гаргасан ерөнхий зөвлөмжийн дагуу No.4(2003) өсвөр үеийн эрүүл мэндэд илүү анхаарч, сургуулиар дамжуулан бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг бэхжүүлэх, хүүхэд залууст ойр, нууцлалыг хадгалсан зөвлөгөө, эмчилгээг нэвтрүүлэхийг даалгаж байна. Мөн сургуульд сурдаггүй хүүхдэд эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл, үйлчилгээг хүргэхэд онцгой анхаарахыг зөвлөж байна. Тамхи татах, архи, мансууруулах бодис хэрэглэхийг багасахын тулд өсвөр үеийнхнийг эрүүл зан үйлийн сонголт хийх чадвартай болгох ажил түгээмэл хийхийг зөвлөж байна.

#### **ДОХ болон Дархлалын олдмол хомсдолын вирус**

47. Дархлалын олдмол хомсдолын вирусийн халдварын түвшин тус оронд харьцангуй бага байгаа болон ДОХ, түүний вирусээс урьдчилан сэргийлэх хууль, үндэсний стратеги, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний бодлого, үндэсний хөтөлбөр зэрэг хууль тогтоомжийг гаргаж, урьдчилан сэргийлэх талаар анхаарч байгааг Хороо тэмдэглэж байна. Хэдийгээр нааштай алхмууд байгаа ч Дархлалын олдмол хомсдолын вирус халдварлах өндөр эрсдэлд байгаа биеэ үнэлэгч залуу хүмүүсийн тоо өсөж буйд санаа зовниж байна

48. Хүүхдийн Эрхийн Хорооноос гаргасан ДОХ болон Дархлалын олдмол хомсдолын вирус болон хүүхдийн эрхийн тухай Ерөнхий зөвлөмж, Хүүхдийн Эрхийн тухай Конвенц, ДОХ болон Дархлалын олдмол хомсдолын вирус, хүний эрхийн тухай олон улсын журам зэрэг баримт бичгийн хүрээнд үүний халдвар тархахаас сэргийлэх, өсвөр үе, ялангуяа эмзэг бүлгийн залууст ойлголтыг нэмэгдүүлэх талаар хүч чармайлтаа нэмэгдүүлэхийг Хорооноос Орлоцогч улсад зөвлөж байна.

49. Орлоцогч улсад ядуурлын түвшин өндөр байсаар байгаад гүнээ харамсаж байна. Хөдөөнөөс хот суурин руу шилжин суурьших явдал нь ядуурлыг хотжуулж, хараа хяналтгүй хүүхэд мэтийн нийгмийн шинэ асуудлыг бий болгосныг тэмдэглэж байна. 2004 онд батлагдсан амьдралын баталгаат түвшнээс доош орлоготой өрхийн хүүхдэд олгох “Итгэлийн мөнгө”, ядуурлыг бууруулах төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийг биелүүлэхэд гаргасан хүчин чармайлтыг тэмдэглэхийн зэрэгцээ хөдөө, хотын аль альд нь амьдрах орон байр, бусад суурь үйлчилгээ гэх мэт амьдралын наад захын хэрэгцээ нь хангагдаагүй хүүхдүүд олон байгаад сэтгэл зовниж буйгаа дахин илэрхийлж байна.

50. Конвенцийн 27 дугаар зүйлд заасны дагуу ядуурлыг бууруулах үндэсний төлөвлөгөөний хэрэгжилтийг сайжруулах, ялангуяа эдийн засгийн бололцоо муутай гэр бүлд онцгой анхаарал хандуулж, дэмжлэг туслалцаа үзүүлэн, амьдралын наад захын стандарт хангагдсан нөхцөлд амьдрах хүүхдийн эрхийг баталгаажуулах шаардлагатайг зөвлөж байна.

**6. Боловсрол, чөлөөт цаг, соёлын арга хэмжээ  
(Конвенцийн 28, 29, 31 дүгээр зүйл)**

**Боловсрол, мэргэжлийн сургалт, зааварчилгаа**

51. Боловсролын стандартыг сайжруулах, 1995 онд шинэчлэн батлагдсан Боловсролын тухай хуулийг хэрэгжүүлэх замаар боловсрол эзэмших боломжийг хангах чиглэлээр авсан арга хэмжээнд талархахын зэрэгцээ боловсрол эзэмших, сургуульд сурах нь зарим хүүхдэд ялангуяа хөдөөгийн хүүхдэд бэрхшээлтэй байсаар байгаад санаа зовж байна. Бага сургуулийн насны олон хүүхэд сургуульд сурахгүй байгаа, сургуульд хамрагдалтын түвшин бүс нутгийн болон жендерийн ихээхэн ялгаатай байгаа, бичиг үсэг үл мэдэх явдал нэмэгдэж байгаа, сургууль завсардалтын түвшин, ялангуяа хөдөөд өсөж байгаа нь санаа зовоох зүйл мөн.

52. Хөдөөгийн малчин өрхийн эрэгтэй хүүхдүүд сургууль завсардаж, хүүхдийн хөдөлмөрт татагдан орох эрсдэл өндөр байгаад харамсаж буйгаа дахин илэрхийлж байна. Сургууль дээр хураадаг элдэв хураамж нь олон гэр бүлд санхүүгийн бэрхшээл учруулж, улмаар хүүхдийн боловсрол эзэмших тэгш эрхээ эдлэхэд нь тээр болж байна. Цаашилбал, хүүхэд сургууль дээрээ хүчирхийлэлд өртөх, сургуулийн хүчин чадал хүрэлцэхгүй байх, ном сурах бичгийн чанар муу байгаад сэтгэл зовж байгаа юм. Сургуулийн дотуур байрыг засварлах, шинээр барихад хийж буй ажлыг сайшаахын зэрэгцээ байрны нөхцөл муу, хүүхдэд үйлчлэх хүчин чадал хязгаарлагдмал байсаар байгаад санаа зовж байна.

53. Дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд шаардагдах санхүү, хүний нөөцийг нэн даруй гаргахыг зөвлөж байна.

- а. Монгол Улсын бүх хүүхэд хүйсийн ялгаа, санхүүгийн аливаа нэг саадгүйгээр, чанартай боловсролыг эзэмших тэгш боломжоор хангах, сургуулийг хүүхдийн гэрт нь ойролцоо байгуулахыг анхаарах;
- б. Бага, дунд сургуулийн хамран сургалтыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг эрчимжүүлэх, бүх хүүхэд бүс нутгийн ялгаагүйгээр боловсрол эзэмших тэгш боломжоор хангах;
- в. Сургууль завсардалт, ялангуяа хөдөө орон нутагт сургууль завсардалтыг багасгах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүч чармайлтаа дайчлах;
- г. Бичиг үсэг үл мэдэх явдал өсөж байгааг бууруулах нэмэлт арга хэмжээ авах;
- д. Сургуульд огт сураагүй, завсардсан өсвөр насны хүүхдэд зориулсан мэргэжлийн сургалт явуулах анги танхим, техник хэрэгслийн хүртээмжийг нэмэгдүүлэх;
- е. Зохих сургалт хийх замаар багш нарын заах арга зүйн чанарыг дээшлүүлэх;
- ё. Шинээр сургууль барих, сургуулийн халаалт, цахилгааны асуудлыг шийдвэрлэх, сурах бичгийн чанар, дотуур байрны нөхцөлийг сайжруулах замаар сурах нөхцөлийг сайжруулах;
- ж. Хорооны Боловсролын зорилгын талаарх 1 дүгээр ерөнхий зөвлөмжийг мөрдлөг болгон хүний эрх, тэр дундаа хүүхдийн эрхийн боловсролыг сургалтын хөтөлбөрт оруулах, сургуулийг хүчирхийллээс ангид, аюулгүй орчин байлгах арга хэмжээ авах.

**Чөлөөт цаг, амралт, соёлын арга хэмжээ**

54. Хот суурин газарт хүүхдийн амралт чөлөөт цаг, соёлын арга хэмжээ цөөн зохиогддог, зориулалтын байр, техник хэрэгсэл ховор, хүүхдэд зориулан барьсан тоглоомын талбайн ихэнх нь өнгөрсөн арван жилийн дотор сүйдсэнд харамсаж буйгаа тэмдэглэж байна.

55. Конвенцийн 31 дүгээр зүйлд заасан хүүхдийн тоглож наадах эрх, амрах, чөлөөт цаг, соёлын арга хэмжээнд хамрагдах эрхийг нь хангахад анхаарал хандуулах, хүүхдийн тоглоомын талбай барих зэрэгт шаардлагатай хүн, хөрөнгө санхүүгийн нөөцийг гаргахад анхаарахыг зөвлөж байна.

**7. Тусгай хамгааллын арга хэмжээ  
(Конвенцийн 22, 30, 38, 39, 40, 37(b)–(d), 32–36 дугаар зүйл)**

**Дүрвэгч хүүхэд**

56. Дүрвэгч хүүхдийн, ялангуяа Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсаас ирсэн хүүхдийг хамгаалах талаар гаргасан тус улсын хүч чармайлтыг Хорооноос үнэлж байна. Гэвч Монголд дүрвэх хүсэлт гаргасан хүүхэд Конвенцэд заасан эрхийнхээ хүрээнд зохих тусламж хамгааллыг авч чадахгүй явдал гардагт санаа зовниж байгаагаа илэрхийлж байна.

57. Конвенцийн 22 дугаар зүйл болон бусад холбогдох заалтын дагуу өмнөх зөвлөмжөө(CRC/C/15/Add.48, 1996 оны 2 дугаар сарын 13, 26 хэсэг) давтан өгч байна. Энэ нь Дүрвэгчийн статусын тухай 1951 оны Конвенц болон түүний 1967 оны Протоколыг хүлээн зөвшөөрч улмаар орогнолын тухай тусгай хууль боловсруулж, уг хуульдаа орогнол хүссэн хүүхэд, ялангуяа дагалдах хүнгүй ганцаар яваа хүүхдэд асрамж хамгаалал үзүүлэх тухай зүйл оруулах, мөн 1954 оны Харьялалгүй иргэний статусын тухай Конвенц, 1961 оны Харьялалгүй байдлыг багасах тухай Конвенцийг хүлээн зөвшөөрөх тухай зөвлөмж өгч байна.

**Эдийн засгийн мөлжлөг**

58. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хүнд хэлбэрийг нэн даруй устгах, хориглох тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 182 дугаар Конвенцэд 2001 онд, хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарын тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 138 дугаар Конвенцэд 2002 онд нэгдэн орж 1999 онд Хөдөлмөрийн тухай хуулиар ажилд орох насны доод хязгаарыг 16 гэж тогтоож, насанд хүрээгүй хүмүүс эрхлэхийг хориглосон хөдөлмөрийн жагсаалт гаргаж, 1999 онд Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах олон улсын хөтөлбөртэй (IPEC) хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурснаас хойш үйл ажиллагаанд нь оролцох болсон зэргээр хүүхдийг хөдөлмөрийн мөлжлөгт ашиглахаас хамгаалагдах эрхийг нь хангахад гаргасан хүч чармайлтад талархаж байна.

59. Хэдийгээр нааштай алхмууд байгаа ч Монголд хөдөлмөр эрхлэгч хүүхдийн тоо олон, хүүхэд сургууль завсардах, хүнд хортой хөдөлмөрийн улмаас эрүүл мэндийн хувьд хохирох зэрэг хөдөлмөрийн мөлжлөгийн олон сөрөг үр дагавар гарсаар байгаад Хороо сэтгэл зовниж байна. Гэрийн үйлчлэгч болон хөдөөгийн хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд

түүнчлэн хүнд хортой нөхцөлд алт, нүүрсний уурхайд хүүхэд ажиллаж байгаа нь туйлын анхаарал татсан асуудал болж байна.

60. Цаашилбал, үндэсний спортоос ашгийн төлөө бизнес болон ихээхэн өөрчлөгдсөн уламжлалт, морины уралдаанд оролцож буй хүүхдийн аюултай нөхцөлд Хорооны зүгээс сэтгэл зовниж байна. Тодруулбал 8 настай хүүхдийг ч уралдаанд оролцуулж тэднийг гэмтэж бэртэх бүр цаашилбал амь насаа алдахад хүргэж байгаад Хороо сэтгэл зовж байна.

61. Дараах чиглэлээр үр дүнтэй, яаралтай арга хэмжээг авахыг Хороо зөвлөж байна.

- а. Хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийг хүнд болон хортой нөхцөлд ажиллуулахыг хориглох зэргээр хүүхдийн хөдөлмөртэй холбоотой хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлэх; Хүүхдийн Эрхийн тухай Конвенцийн 32 дугаар зүйл, Монгол Улс нэгдэн орсон Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 138, 182 дугаар Конвенц, 146, 190 дүгээр Зөвлөмжийг биелүүлэх замаар гэрийн үйлчлэгчийн болон хөдөөгийн хөдөлмөр, хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх;
- б. Мэргэшсэн хөдөлмөрийн байцаагчдыг нэмэгдүүлэх замаар хүүхдийн хөдөлмөрийн хяналтыг дээшлүүлэх;
- в. Хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийг мэргэжлийн болон албан бус боловсролын хэлбэрээр чанартай боловсрол олох боломжоор хангах, тэд сурч боловсрох, амрах, тоглох, чөлөөт цагтай байх нөхцөлийг хангах;
- г. Гэрийн үйлчлэгчийн болон хөдөөгийн хөдөлмөр, ер нь хүүхдийн хөдөлмөрийн сөрөг үр дагавруудын талаар хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчдын ойлголтыг нэмэгдүүлэх ажлыг өрнүүлэх замаар хүүхдийн хөдөлмөрийн талаар олон нийтийн хандлагыг өөрчлөх;
- д. Морин уралдааны бизнест хүүхэд хэдий хэмжээгээр, ямар байдлаар мөлжигдөж байна гэдгийг тогтоох тодорхой судалгаа явуулах, уралдааны морь унаж байгаа хүүхдийн насыг хөдөлмөр эрхлэх насны доод хязгаар гэж Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан 16 нас байхаар тогтоож түүнээс доош насны хүүхдийг хурдан морь унуулахыг хориглох;
- е. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ILO/IPEC)–аас тусламж авахаа үргэлжлүүлэх

### **Хараа хяналтгүй хүүхэд**

62. Хараа хяналтгүй хүүхдийн нөхцөл байдлын талаар хангалттай мэдээлэл өгөөгүйд харамсаж буйгаа илэрхийлж байна. Хараа хяналтгүй хүүхдэд зориулсан халамжийн төвүүдийг байгуулсныг талархан тэмдэглэж байгаа ч маш хүнд нөхцөлд амьдарч байгаа хараа хяналтгүй хүүхдийн тоо нэмэгдсээр байгаа, энэ байдалд хүргэж байгаа шалтгаан нь ихэнхдээ гэр бүлийн хүчирхийлэл, доромжлол байдагт сэтгэл зовж байна. 1994 оны 7 дугаар сард батлагдсан “Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай” хуулиар гэрээсээ дайжсан хүүхдийг нэг долоо хоног хүртэл хорьж болохоор заасан нь тус улсын хууль тогтоомж конвенцийн зарчимтай бүрэн нийцэхгүй байгааг харуулж байна. Мөн хараа хяналтгүй хүүхдийг гадуурхах олон нийтийн хандлага нь эдгээр хүүхдийн хүнд амьдралыг улам хэцүү болгож байна.

63. Хорооноос зөвлөх нь:

- а. Хараа хяналтгүй хүүхдийн асуудлыг шийдвэрлэх үндэсний, иж бүрэн стратегийг боловсруулж хэрэгжүүлэх, энэ ажлын хүрээнд хамгийн эмзэг бүлгийнхэнд онцгой анхаарал хандуулж, тэдний өсөлт хөгжлийн бүхий л хэрэгцээг хангахын тулд мэргэжлийн болон амьдрах ухааны сургалтад хамруулах, бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн, архи, хорт бодист донтсон хүүхдэд үзүүлэх нөхөн сэргээх, нийгэмшүүлэх зэрэг үйлчилгээнүүдийг бий болгох;
- б. 1994 оны 7 дугаар сард батлагдсан “Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай” хуульд зааснаар гэрээсээ дайжсан хүүхдийг цагдан хорих бодлогыг түдгэлзүүлж, конвенцийн заалттай бүрэн нийцэх бусад хэлбэрийг хайн ажиллах;
- в. Хүүхэд хараа хяналтгүй болохоос сэргийлэх, гудамжинд амьдарч байгаа хүүхдэд хэрэгцээнд нь нийцсэн үйлчилгээ үзүүлэх, тэднийг гэр бүлдээ эргэж очих боломжоор хангахын тулд гудамжинд амьдрах болсон үндсэн шалтгаан, учир холбогдол, зан чанарыг ойлгох судалгаа хийх;
- г. Хараа хяналтгүй хүүхдийн тухай олон нийтийн сөрөг хандлагыг өөрчлөх, ойлголтыг нэмэгдүүлэх;
- д. Хараа хяналтгүй хүүхэд болон тэдэнтэй ажилладаг төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, НҮБ-ын Хүүхдийн Сан болон бусад байгууллагаас техникийн тусламж авах.

#### **Бэлгийн мөлжлөг ба хил дамнан худалдаалах**

64. Биеэ үнэлж буй хүүхдийн тоо өссөөр байгаад маш их эмзэглэж байна. Хүүхдийг хил дамжуулан худалдах нь Монгол Улсад хүний эрхийн зөрчлийн харьцангуй шинэ үзэгдэл гэдгийг Хороо тэмдэглэхийн зэрэгцээ ядуурал, ажилгүйдлийн өсөн нэмэгдэж буй түвшин, хүүхэд гэрээсээ дайжихад хүргэж байгаа гэр бүлийн хүнд нөхцөл болон аялал жуулчлал өсөн нэмэгдэж байгаатай холбоотойгоор хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашиглах ба хил дамжуулан худалдаалах эрсдэлийг өсгөж болзошгүй хүчин зүйлүүд олон байгаад сэтгэл зовниж байна.

65. Хүүхдийг бэлгийн мөлжлөгт болон бусад хэлбэрээр ашиглахаар хил дамжуулан худалдаагаас сэргийлэх, үүнтэй тэмцэхэд дараах арга хэмжээ авахыг зөвлөж байна:

- а. Хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашиглах, хил дамжуулан худалдаагаас сэргийлэх, үүнтэй тэмцэх үндэсний бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх, хүүхдийг ийм эрсдэлд оруулж байгаа хүчин зүйл, уг шалтгааныг арилгахад анхаарах;
- б. Хүнийг хил дамжуулан худалдсан хэргийг илрүүлэх, мөрдөх тухай хууль тогтоомж, хүч чармайлтыг бэхжүүлэх, хил дамжуулан худалдах асуудлын тухай ойлголтыг дээшлүүлэх, буруутай этгээдэд хуулиар хариуцлага хүлээлгэх,
- в. Хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашиглахын эсрэг 1996, 2000 оны Дэлхий нийтийн амлалт, үйл ажиллагааны тунхаглалтай уялдуулан бэлгийн мөлжлөгт өртсөн болон хил дамжуулан худалдагдсан хүүхдэд нөхөн сэргээх, туслах үйлчилгээ, хөтөлбөрийг хангалттай хэрэгжүүлэх;
- г. Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх тухай” конвенц (2000), “Хүнийг, тэр дундаа эмэгтэйчүүд, хүүхдийг хил

дамжуулан худалдах, хэргийг нуун дарагдуулахаас сэргийлэх, буруутай этгээдийг шийтгэх тухай” протоколыг соёрхон батлах.

**Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудлыг зохицуулах**

66. 1999 онд “Хүүхдийн гэмт хэрэг болон хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр” баталсан, Цагдаагийн ерөнхий газрын Хүүхдийн тасгийг өөрчлөн зохион байгуулсан, 18 нас хүрээгүй хүмүүст тусгайлан зориулсан хуулийн заалтыг оруулсан, Эрүүгийн хуулийг 2002 онд шинэчлэн баталсан зэрэг хууль зөрчсөн хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэсэн хүч чармайлтыг үнэлж байна. Гэвч 18 насанд хүрээгүй хүмүүсийг урьдчилан хорих байранд удаан хугацаагаар хорих, ноцтой биш гэмт хэрэгт анх удаа холбогдсон хүүхдийг хорих ялаар шийтгэх явдал байсаар байгаад сэтгэл зовниж байна. 18 насанд хүрээгүй хууль зөрчсөн хүмүүс хуулийн зөвлөгөө туслалцаа авах боломжгүй байгаад Хороо сэтгэл зовж байна. Урьдчилан хорих байр, шоронгийн нөхцөлийг сайжруулах талаар зарим нэг нааштай зүйл хийгдсэн ч эдгээр газарт хүүхэд амьдрах нөхцөл хангалтгүй байсаар байгааг Хороо тэмдэглэж байна.

67. 18 нас хүрээгүй хөвүүд Улаанбаатар хотод байгаа хүүхдийн тусгай шоронд ял эдэлдэг боловч охидыг насанд хүрсэн эмэгтэйчүүдтэй нэг шоронд хорьж байна. 18 нас хүрээгүй ял эдэлж байгаа болон суллагдсан хүмүүст зориулсан нийгэмшүүлэх үйлчилгээ хомс байгаад сэтгэл зовниж байна. Насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг шийдвэрлэх хууль тогтоомж 18 нас хүрээгүй хүмүүсийг тэнсэн суллах талаар хүндрэл учруулахаар байгаад Хороо эмзэглэж буйгаа илэрхийлье. Түүнчлэн шүүхийн үйл ажиллагаа хүүхдэд мэдрэмжтэй байж чадахгүй байгаа бөгөөд энэ талаар конвенцийн заалтыг хангах хэмжээнд сургагдаж бэлтгэгдээгүй байгаад эмзэглэж байна.

68. Хүүхдийн гэмт хэргийн асуудлаарх Ерөнхий хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжийн дагуу тус улсыг Нэгдсэн Үндэстний Байгууллагаас гаргасан “Насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг шүүн таслах ажиллагаа явуулахтай холбоотой наад захын дүрэм” (Бээжингийн дүрэм), “Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын үндсэн зарчим” (Риядын үндсэн зарчим), “Эрх чөлөө нь хязгаарлагдсан насанд хүрээгүй хүнийг хамгаалах тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын журам, “Гэмт хэргийн улмаас хуулийн системд байгаа хүүхдэд үзүүлэх арга хэмжээний тухай” Венийн дүрэм болон Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 37, 40, 39 дүгээр зүйл, насанд хүрээгүй хүмүүсийн эрхийг хамгаалах стандартыг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч дараах арга хэмжээ авахыг зөвлөж байна.

- а. Хүүхдийн гэмт хэрэгтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх зорилготой үндэсний хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх, бүх аймагт сайтар бэлтгэгдсэн мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн хүүхдийн шүүх байгуулах;
- б. 18 нас хүрээгүй хүмүүсийг хорих ялын хугацааг хуулиар богиносгох;
- в. 18 нас хүрээгүй хүмүүсийг урьдчилан хорих байранд байлгах хугацааг хуулиар богиносгох, аргагүй тохиолдолд зөвхөн шүүгчийн зөвшөөрөлтэйгөөр аль болох бага хугацаагаар хорих, хорьсны дараа хугацааг заавал шалгаж үзэх;

- г. 18 нас хүрээгүй хүмүүсийг хорихоос өөр ялаар шийтгэх хувилбарууд, тухайлбал тэнсэн харгалзах, олон нийтийн ажил хийлгэх, ялыг хойшлуулах зэрэг хувилбарыг хөгжүүлэх;
- д. Хорихоос өөр ял онохоос аргагүй тохиолдолд баривчлах, хорих үйл ажиллагааны нөхцөлийг сайжруулах;
- е. 18 нас хүрээгүй хүмүүс зохих хууль зүйн тусламж, өмгөөлөгч авах боломж олгох, бусдаас хамааралгүйгээр, хүүхдэд ээлтэй нөхцөлд мэдүүлэг өгөх механизм бүрдүүлэх;
- ё. Хүүхдийн гэмт хэргийн асуудал хариуцдаг албан тушаалтанд зориулан олон улсын холбогдох стандартуудын талаар сургалт хийх, хууль зөрчсөн хүүхэдтэй ажиллах нийгмийн ажилтны ажлын байрыг хорих газар бий болгох;
- ж. 18 нас хүрээгүй ял эдэлж байгаа болон суллагдсан хүмүүсийг мэргэжлийн болон амьдрах ухааны сургалтад хамруулах, нөхөн сэргээх, нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх зэргээр тэдний хөгжлийн хэрэгцээг хангах, сурч төлөвших боломжоор хангах;
- з. НҮБ-ын Хүний эрхийн дээд Комиссарын Ажлын Алба, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Мансууруулах бодис, гэмт хэргээс сэргийлэх алба, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан зэрэг байгууллагаас техникийн тусламж авах, тэдэнтэй хамтран ажиллах.

#### **Үндэстний цөөнхийн хүүхэд**

69. Конвенцийн 30 дугаар зүйлд заасны дагуу үндэстний цөөнхийн хүүхэд болох казах, цаатан хүүхдийн эрхийг хамгаалах талаар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж буй талаар мэдээлэл тайланд байгаагүйгээс Хороо дүгнэлт хийх боломжгүй байгаад харамсаж байна. Эдгээр хүүхдийн боловсрол эзэмших, эрүүл мэнд нийгмийн үйлчилгээ хүртэх зэрэг эрхээ эдлэх явдал хязгаарлагдмал байгаад Хороо зовниж байна.

70. Конвенцийн 2, 30 дугаар зүйлд заасан үүргээ биелүүлж, үндэстний цөөнхийн хүүхдийг хүний эрхээ ямар нэг ялгаваргүйгээр, тэгш эдлэх боломжоор хангахыг зөвлөж байна. Хэл, шашин, гарал үүсэл, өөр үндэстний цөөнхийн хүүхдийн талаар конвенцийн 30 дугаар зүйлд заасан үүргээ хэрхэн биелүүлж байгаа талаар дараагийн илтгэлдээ тодорхой, дэлгэрэнгүй тусгахыг хүсэж байна.

### **8. Хүүхдийн Эрхийн тухай Конвенцийн Нэмэлт Протокол**

71. Хүүхдийн Эрхийн конвенцийн Хүүхдийг худалдах, садар самуунд уруу татагдахаас хамгаалах талаар нэмэлт протоколд 2003 оны 6 дугаар сард, Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахаас хамгаалах нэмэлт протоколд 2004 оны 10 дугаар сард нэгдэн орсонд талархаж байна.

72. Хүүхдийн эрхийн конвенцийн нэмэлт протоколын хэрэгжилтийг шалгахын тулд тайланг цаг хугацаанд нь тогтмол өгч байхыг хүсэж байна. Хүүхдийн эрхийн конвенц, нэмэлт протоколын биелэлтийг тайлагнах үүргээ бүрэн биелүүлэхийг тус улсаас хүсье.



## 9. Зөвлөмжийг түгээх, хэрэгжүүлэх

### Зөвлөмжийг хэрэгжүүлэх

73. Энэхүү зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авах, тэр дундаа зөвлөмж нь Улсын Их Хурал, Засгийн Газар, Засгийн Газрын гишүүд болон түүнтэй адилтгах өндөр зэрэглэлийн албан тушаалтан, аймаг нийслэлийн Засаг дарга, Иргэдийн хурлын дарга нарт хүрсэн, тэдний үйл ажиллагаанд тусгалаа олсон байх бүх арга хэмжээг авахыг гишүүн улсад зөвлөж байна.

### Түгээх

74. Хоёрдугаар тайлан, бичгээр өгсөн хариулт болон дүгнэлт зөвлөмжийг олон нийт, иргэний нийгэм, хүүхэд залуус, тэдний байгууллага, мэргэжлийн албад зэрэг нийгмийн бүхий л хүрээнд гишүүн улсад хэрэглэдэг бүх хэлээр түгээж /интернэтэд байрлуулах болон бусад бүх арга замаар/ өргөн олноор хэлэлцүүлэх, конвенцийн тухай болон түүний хэрэгжилт, хяналтын тухай олон нийтийн ойлголтыг дээшлүүлэхийг зөвлөж байна.

## 10. Дараагийн тайлан

75. Хүүхдийн Эрхийн Хороонд гишүүн улс конвенцийг хэрхэн хэрэгжүүлж байгааг байнга хянах боломжоор хангах үүргийнхээ дагуу Хорооны 29 дүгээр хуралдааны тайланд зааснаар (CRC/C/114), конвенцийн 44 дүгээр зүйлд заасны дагуу хугацаандаа тайлагнахын чухлыг онцлон тэмдэглэж байна. Зарим улс тайлангаа тогтмол, цаг хугацаанд нь бэлдэхэд учирдаг бэрхшээлийг Хороо мэддэг. Иймд Хорооноос гишүүн улсыг тайлангаа хугацаанд нь тавих үүргээ биелүүлэхэд нь туслах зорилгоор гурав, дөрөвдүгээр тайлангаа нэгтгэн бэлтгэж, 2007 оны 9 дүгээр сарын 1-ээр эцсийн хугацаа болгон Дөрөвдүгээр тайлангаа ирүүлэхийг урьж байна. Илтгэл 120 хуудаснаас хэтрэхгүй байна. Түүний дараагаас Конвенцэд заасны дагуу 5 жил тутамд тайлангаа тогтмол ирүүлнэ гэдэгт итгэж байна.

**6.4 ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ НҮБ–ЫН КОНВЕНЦИЙН ХЭРЭГЖИЛТИЙН  
ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ГУРАВ, ДӨРӨВДҮГЭЭР  
ТАЙЛАН ИЛТГЭЛ**

2007 оны 10 дугаар сарын 10–ны өдөр

Улаанбаатар хот

**Хураангуй**

Монгол Улсын Засгийн газар Хүүхдийн эрхийн тухай НҮБ–ын конвенцийн хэрэгжилтийн талаарх ээлжит 3 ба 4 дэх тайлангаа нэгтгэн боловсруулсан үндэсний дөрөвдүгээр тайлан илтгэлийг НҮБ–ын Хүүхдийн эрхийн хороонд өргөн барьж байна. Энэхүү үндэсний дөрөвдүгээр тайлан илтгэлийг Хүүхдийн эрхийн хорооноос гаргасан Хүүхдийн эрхийн тухай конвенцийн тайлан боловсруулах ерөнхий заавар, удирдамж, түүнчлэн Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын хоёрдугаар илтгэлийг танай хороогоор хэлэлцэж гаргасан дүгнэлт, зөвлөмжийн дагуу бэлтгэсэн болно. Үндэсний тайлан илтгэл удиртгал болон үндсэн найман бүлгээс бүрдэх төдийгүй зарим шаардлагатай статистикийн үзүүлэлт, бусад нэмэлт мэдээллийг хавсаргав.

Тайлангийн хугацаанд Монгол Улсын Засгийн газар Хүүхдийн эрхийн тухай конвенцийн заалт болон Хүүхдийн эрхийн хорооноос ирүүлсэн дүгнэлт, зөвлөмжийг биелүүлэх ажлыг Хүүхдийн хөгжил, хамгааллыг 2002–2010 онд сайжруулах үндэсний хөтөлбөрийн 2005–2007 оны үйл ажиллагааны чиглэлд тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авлаа.

Тайлангийн хугацаанд Монгол Улсын эдийн засагт гарсан эерэг өөрчлөлт, олон улсын банк, санхүүгийн байгууллага, хандивлагч улс орнуудын техникийн болон санхүүгийн дэмжлэг тусламж, манай иргэд, олон нийт, өсвөр үеийнхний өргөн оролцоо дэмжлэг Хүүхдийн эрхийн тухай конвенцийг үр дүнтэй хэрэгжүүлэх нэг таатай орчин нөхцөл болсныг тэмдэглэж байна. Энэ хугацаанд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн өсөлт 6–10 хувьд, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 950 ам.долларт хүрэв. Засгийн газар 2004–2006 онуудад дотоодын нийт бүтээгдэхүүний 13–18 хувьтай, улсын төсвийн 47–50 хувьтай тэнцэхүйц хөрөнгийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбарт зарцуулсан байна. Түүнчлэн Монгол Улсыг хөгжүүлэх санг 2006 онд зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын орлогын эх үүсвэрт суурилан байгуулсан бөгөөд түүний хөрөнгийн бараг тэн хагасыг буюу зуун дөч гаруй тэрбум төгрөгийг 2007 онд хүүхэд, гэр бүлийг дэмжих арга хэмжээнд шууд хуваарилан олгосон байна.

Хүүхдийн эрхийн тухай конвенцийн үзэл санаанд нийцүүлэн хүүхдийн эрх ашгийг нэн түрүүнд хангах, хүүхдийг сургууль, гэр бүлийн орчинд хүчирхийллээс ангид байлгах, тэдний өсөн хөгжих эрүүл, таатай орчин нөхцөлийг хангах эрх зүйн хамгааллыг бүрдүүлэхэд чиглэсэн 20 гаруй хуулийг Монгол Улсын Их Хурал шинээр болон шинэчлэн найруулж баталсан байна. Үүний дотор Боловсролын тухай, Бага, дунд боловсролын

тухай, Нийгмийн халамжийн тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай, Давсыг иоджуулж, иод дутагдлаас урьдчилан сэргийлэх тухай, Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний тухай, Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг хуулийг онцлон дурдаж болох юм. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт гэр бүл, хүүхдийн эрхийг хангахтай холбоотой олон асуудлыг тусган шат дараатай хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газар хүүхэд, өсвөр үеийнхний бодлогыг Монгол Улсын Шадар сайдын эрхлэх үндсэн хүрээний ажилд хамааруулах болсноор хүүхэд хамгааллын салбар хоорондын ажлын зохицуулалт, уялдааг сайжруулах нөхцөл бүрдлээ. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг–Хүүхдийн төлөө үндэсний газрын хүүхдийн эрхийн салбар хоорондын ажлын уялдаа, зохицуулалтыг хангах чадавхийг хөгжүүлэхэд илүүтэй анхаарч ажиллаж байна. Аймаг, нийслэлийн түвшинд Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхдийн төлөө хэлтсүүд үйл ажиллагааны шинэ стратегиар ажиллаж, орон нутагт хүүхдийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чиглэлээр өргөн хүрээнд хамтран ажиллах эхлэл тавигдлаа.

Гэр бүл, хамт олны хүрээнд хүүхдийн амьдрах таатай орчин нөхцөлийг сайжруулахад чиглэсэн өрхийн тогтвортой амьжиргааг дэмжих, хүн амыг усан хангамж, орон сууцаар хангах зэрэг төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд орон нутгийн эрчим хүч, авто зам, худалдаа, үйлчилгээний зэрэг сүлжээг шинэчлэн байгуулах замаар хөдөөгийн иргэдийн ахуй амьдралыг сайжруулах бодлогыг тууштай хэрэгжүүлж байна. Нийгмийн нөөц баялгийн хуваарилалтын хүн амд үзүүлэх үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор хүүхэд залуу гэр бүлд үзүүлэх мөнгөн тэтгэмжийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Эдгээр арга хэмжээний дүнд гэр бүлийн гишүүдийн зүгээс хүүхдэд тавих анхаарал халамж нэлээд сайжирч байна.

Засгийн газар хөдөө орон нутагт амьдардаг болон нийслэлд шилжин суурьшиж байгаа хүүхдийн сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс цэцэрлэг, сургуулийн барилга шинээр барих, өргөтгөх, засварлах ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалт болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлыг эрчимтэй зохион байгуулж байна. Зөвхөн 2006 онд нийт 7052 хүүхдийн суудал бүхий 17 сургууль, 590 хүүхэд хүмүүжүүлэх хүчин чадал бүхий 5 цэцэрлэг, 130 хүүхдийн хүчин чадал бүхий сургуулийн дотуур байрыг шинээр ашиглалтад оруулсны зэрэгцээ 118 сургууль, цэцэрлэг, дотуур байрны барилгыг засварласан байна. Ерөнхий боловсролын сургууль завсардалтыг бууруулах, хүүхдэд ээлтэй сурах орчин бүрдүүлэх, сургалтын агуулгыг олон улсын жишигт нийцүүлэх чиглэлд тодорхой ахиц гарлаа. Монгол Улсын Боловсролыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд 2006–2015 онуудад цэцэрлэгийн хүчин чадлыг 7.8 мянгаар, ерөнхий боловсролын сургуулийн суудлын тоог 69.6 мянгаар, дотуур байрны орны тоог 5.0 мянгаар, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн суудлын тоог 3.8 мянгаар тус тус нэмэгдүүлэхээр тусгасан байна.

Монгол Улсын Засгийн газраас “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Хүүхдийн өвчний цогц менежмент”, “Сумын эмнэлгийн хөгжил”, “Эрүүл мэндийн технологийг сайжруулах”, “Эрүүл Монгол хүн” зэрэг хөтөлбөрийг хэрэгжүүлж, улмаар эх, хүүхдэд чиглэсэн эрүүл

мэндийн болон эмнэлгийн үйлчилгээг дэмжсэнээр эх, хүүхдийн эндэгдэл, бага насны хүүхдийн хоол, тэжээлийн дутал буурч байна.

Хүүхдийн төлөө тавих анхаарал, хүчин чармайлт дээшилж байгаа хэдий ч шийдэж чадаагүй цөөнгүй асуудал байсаар байна. Хот, хөдөөгийн болон хүн амын амьжиргааны түвшний ялгаа хүүхдийн амьдралд хүнд туссан хэвээр байна.

Хууль зөрчсөн, гэмт хэргийн улмаас хохирсон, хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгт өртсөн, хараа хяналтгүй орхигдсон, хөгжлийн бэрхшээлтэй, нэн ядуу амьдарч байгаа хүүхдийн болон гадаад оронд ажиллаж амьдардаг монгол иргэдийн хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, бүх шатанд хүүхэд хамгааллын тогтолцоог боловсронгуй болгох, орон нутгийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх шинэ шаардлага урган гарч байгааг хүлээн зөвшөөрч, хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангах, түүнд тавих хяналтыг сайжруулах, хүүхдийн талаарх төрийн мэдээллийн тогтолцоог хөгжүүлэх явдал чухал байна. Монгол Улсын Засгийн газар эдгээр тулгамдсан асуудалд ойрын жилүүдэд илүү анхаарал хандуулж ажиллах болно.

### Удиртгал

1. Монгол Улсын Засгийн газар Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн 44 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн энэхүү конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын гурав, дөрөв дэх тайлан илтгэлийг нэгтгэн танилцуулж байна.

2. Хүүхдийн эрхийн хороо Монгол Улсын хоёрдугаар илтгэлийг 2003 оны 5 дугаар сард хүлээн аваад 2005 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 1040, 1041 дүгээр хуралдаанаар хэлэлцэж, мөн оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 1052 дугаар хуралдаанаас дүгнэлт, зөвлөмж гаргасан юм. Энэхүү зөвлөмжид Монгол Улс ээлжит 3 ба 4 дэх тайлангаа нэгтгэн бэлтгэж, 2007 оны 9 дүгээр сарын 1-нээр тасалбар болгон дөрөвдүгээр тайлан илтгэлээ ирүүлэхийг хүссэн билээ.

3. Монгол Улсын дөрөвдүгээр илтгэлийг Хүүхдийн эрхийн хорооноос 2005 онд гаргасан CRC/C/58/Rev.1 тайлан бэлтгэх удирдамжийн дагуу боловсрууллаа. Энэхүү тайлан илтгэлд Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх 2004–2007 оны үйл ажиллагаа болон 2004–2006 оны холбогдох статистикийн үзүүлэлт, мэдээллийг багтаасан болно.

4. Монгол Улсын Засгийн газар Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенц, энэхүү конвенцийн нэмэлт протоколуудын хэрэгжилтийн талаарх үндэсний тайлан илтгэлийг боловсруулах ажлын хэсгийг 2007 оны 4 дүгээр сард төрийн болон төрийн бус байгууллага, хүүхдийн төлөөллийн оролцоо бүхий бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажиллуулсан юм. Ажлын хэсэг тайлан бэлтгэх үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө, хуваарийг батлуулан түүний дагуу сонирхогч талуудтай хамтран шаардлагатай мэдээллийг цуглуулах, тайлан илтгэлийн бүрэлдэхүүн хэсгийг боловсруулах ажлыг 4–6 дугаар саруудад гүйцэтгэж, улмаар тайлан илтгэлийн төслийг 7 дугаар сард нэгтгэн боловсруулж, төслийг төрийн ба төрийн бус байгууллага, олон нийт, хүүхдийн төлөөлөгчдөөр 8 дугаар сард хэлэлцүүлж, түүнд төрийн захиргааны төв байгууллагуудын санал авах ажлыг 9 дүгээр сард зохион байгууллаа. Монгол Улсын

дөрөвдүгээр тайлан илтгэлийн эцэслэн боловсруулсан хувилбарыг Засгийн газрын 2007 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанд танилцуулан зөвшөөрөл авсан байна.

5. Тайлан илтгэлийг боловсруулах үйл ажиллагаанд хүүхдийн чиглэлээр ажилладаг 30 гаруй төрийн бус байгууллага идэвхтэй оролцож, хамтран ажиллалаа. Мөн тайлан илтгэлийг боловсруулах ажилд нийслэлийн ба орон нутгийн нийт 2000 гаруй хүүхдийн саналыг тусган тайлангийн төслийг 100 орчим хүүхдээр тусгайлан хэлэлцүүлээ.

6. Монгол Улсын дөрөвдүгээр тайлан илтгэлийг боловсруулах ажилд НҮБ-ын Хүүхдийн сан бүх талын дэмжлэг үзүүлж ажилласан болно.

7. Тайлан илтгэлд дурдсан Монгол Улсын Засгийн газрын бодлого, эрх зүйн баримт бичгүүдээс шаардлагатай гэж үзсэн мэдээллийг сонгон англи хэлэнд орчуулан хавсаргасан болно. Хүүхдийн эрхийн хороо хүссэн тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын бодлогын ба эрх зүйн баримт бичгийг англи хэл рүү хөрвүүлэн илгээх боломжтой юм.

**Нэгдүгээр бүлэг. Хэрэгжилтийн ерөнхий арга хэмжээ**  
(Конвенцийн 4 ба 42 дугаар зүйл, 44 дүгээр зүйлийн 6 дахь заалт)

**Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн өнөөгийн байдал**

8. Тайлангийн хугацаанд Монгол Улсын эдийн засаг сайжран дотоодын нийт бүтээгдэхүүн жилд 6–10 хувиар өссөн байна. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 2005 онд 744 ам.доллар, 2006 онд 950 ам.долларт хүрч нэмэгдлээ. Эдийн засгийн өсөлт уул уурхай, үйлчилгээний салбарын хөгжилтэй холбоотой төдийгүй дэлхийн зах зээл дэх алт, зэсийн үнийн өсөлт бас нөлөөлж байна. Улсын төсвийн зарлага 2004 онд 752.5 тэрбум төгрөг байсан бол 2006 онд 1237.0 тэрбум төгрөгт хүрч 64.4 хувиар өссөн байна. Монгол Улсын Засгийн газар 2004–2006 оны хугацаанд дотоодын нийт бүтээгдэхүүний 13–18 хувь, улсын төсвийн 47–50 орчим хувийг нийгмийн үйлчилгээний салбарт зарцуулсан байна.

9. Улсын Их Хурлын 2004 оны сонгуулиар Монгол Ардын Хувьсгалт Нам болон Ардчилсан эвсэл холбоод ойролцоо тооны суудал авснаар Их эвслийн болон Үндэсний эв нэгдлийн Засгийн газрыг байгуулан ажиллаж байна. Тайлангийн хугацаанд улсын төсвийн орлого нэмэгдэхийн хэрээр орон нутагт чиглэсэн төсвийн хуваарилалтын болон хөрөнгө оруулалтын уян хатан бодлогыг явуулах боллоо. Монгол Улсын Засгийн газраас нийгмийн салбарт, ялангуяа гэр бүл, хүүхдийн амьдрах таатай орчныг бүрдүүлэх, тэдэнд чиглэсэн шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлогыг илүүтэй хэрэгжүүлж байна.

10. Бүсийн тулгуур төв хотуудыг тогтоож, тэдгээрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон манай орны эдийн засгийн таван бүсийн хөгжлийн хөтөлбөр, тэрхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө зэргийг Засгийн газрын 2005 оны 201, 202 дугаар тогтоолоор батлан, хэрэгжилтийг хангах чиглэлээр шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсөвт тусгах, гадаадын зээл, тусламжийн төсөлд хамруулах ажлыг үе шаттай зохион байгуулж байна.

11. Монгол Улсад амьжиргааны доод түвшнээс доогуур амьжиргаатай хүн амын хувийн жин 1990 онд 36.3 хувь байсан бол 2000 онд 35.1 хувь, 2005 онд 36.1 хувь

гэсэн судалгаа гарсан байна. Амьдралын наад захын хэрэгцээ, төрийн үйлчилгээний зах зухаас ч болов хүртэх хүсэл эрмэлзэлд хөтлөгдөн хот суурин газрыг чиглэсэн их нүүдэл саарахгүй байна. Хүүхэд ядууралд өртөх нь эцэг эх, гэр бүлийн ядууралтай холбоотой байна. Ядуурал орлогын болон боломжийн гэсэн агуулгатай байна. Өрхийн орлогын ядуурал нь олон хүүхдийн хөгжлийн үр шимийг хүртэх боломжийг хязгаарлан тэднийг гудамжинд амьдрах, хүнд хүчир хөдөлмөр эрхлэх, биеэ үнэлэх, гэмт хэрэгт өртөх шалтгаан болсоор байна.

**12.** Монгол Улс Мянганы хөгжлийн зорилтыг ханган биелүүлэхийн төлөө ажиллаж байна. Хэдийгээр хүүхдийн эрхийг хамгаалах асуудлаар тодорхой амжилт, ололт байгаа хэдий ч тулгамдсан, шийдвэрлэж хараахан чадаагүй олон асуудал байсаар байна. Хүнд нөхцөлд байгаа хүүхдийн эрхийг хамгаалах, ялангуяа тэдний нийгмийн үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх, хамгааллыг сайжруулах асуудал хангалтгүй хэвээр байна.

**(11). Конвенцийн зарчимд дотоодын хууль, тогтоомжийг нийцүүлэхээр авсан арга хэмжээ**

**13.** Монгол Улс Хүүхдийн эрхийн тухай конвенцийг бүхэлд нь хүлээн зөвшөөрч 1990 онд нэгдэн орж соёрхон баталсан билээ. Түүнчлэн Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд татагдахаас хамгаалах нэмэлт протокол болон Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахаас хамгаалах нэмэлт протоколд бүхэлд нь 2001 онд нэгдэн орсон бөгөөд тэдгээрээс хэрэгжүүлэхээс татгалзсан болон хойшлуулсан зүйл, заалт байхгүй болно.

**14.** НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны 2005 оны 39 дугаар чуулганаас хүүхдийн эрхийн асуудлаар Монгол Улсад өгсөн дүгнэлт, зөвлөмжийн аравдугаар заалтын хүрээнд дотоодын хууль тогтоомжийг Хүүхдийн эрхийн тухай конвенцийн зарчмууд болон хэм хэмжээтэй нийцүүлэх талаар тодорхой арга хэмжээг авсаар байна.

Монгол Улсын Их Хурал Монгол Улсын хууль тогтоомжийг 2008 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийг баталсан бөгөөд түүнд Нийгмийн халамжийн тухай, Гэр бүлийн тухай, Боловсролын тухай, Эрүүгийн, Эрүүгийн байцаан шийтгэх зэрэг хуульд хүүхдийн эрхийг баталгаажуулах чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгасан байна. Энэ хүрээнд Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай (2006), Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай (2006), Давсыг иоджуулж, иод дутагдлаас урьдчилан сэргийлэх тухай (2005), Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний тухай (2005), Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдлоос сэргийлэх тухай (2004) зэрэг хуулийг шинээр батлуулснаас гадна Хүүхдийг эрхийг хамгаалах тухай, Боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай, Эрүүгийн, Эрүүгийн байцаан шийтгэх зэрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Хууль зүй, дотоод хэргийн яам “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн” сэдвээр шинэ Үндсэн хууль батлагдсанаас (1992 оноос) хойш гарсан хууль тогтоомжийг шинэтгэх үйл явцад 2007 онд үнэлгээний ажил хийж, дүнг хэлэлцүүлж байна. Мөн Хөдөлмөрийн тухай хуульд “насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтад харшлахгүй бол 15 насанд хүрсэн хүн эцэг, эх

буюу харгалзан дэмжигчийн зөвшөөрөлтэйгээр хөдөлмөрийн гэрээ байгуулж болно. Мөн мэргэжлийн баримжаа, ажлын дадлага олгох зорилгоор 14 насанд хүрсэн хүнтэй эцэг эх, асран хамгаалагч болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгээр хөдөлмөрийн гэрээ байгуулж болно” гэсэн заалт хүүхдийн сурч боловсрох настай зөрчилдөж байгаа талаар Хүүхдийн эрхийн хорооноос ирүүлсэн зөвлөмжид дүгнэсэн билээ. Засгийн газар зөвлөмжийн энэ хэсгийг судалж байгаа бөгөөд өнөөгийн нөхцөлд өөрчлөх бололцоо бага байна.

**15.** Монгол Улсын Засгийн газар Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын хоёрдугаар тайлан илтгэлээ өргөн барьсантай холбогдуулан Хүүхдийн эрхийн хорооноос 2005 онд ирүүлсэн дүгнэлт, зөвлөмжийн арван хоёрдугаар заалтыг удирдлага болгон ажиллаж байна. Хүүхдийн эрхийг хамгаалах төрийн байгууллагын чадавхийг хөгжүүлэх, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал зэрэг салбарын нийгмийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй, нийгмийн эмзэг бүлэгт байгаа хүүхдийн амьдралын боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос ирүүлсэн дүгнэлт, зөвлөмжийг олон нийтэд сурталчлах, тэднээр хэлэлцүүлэх замаар “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах (2002 – 2010 оны) үндэсний хөтөлбөрийн хоёр дахь шат буюу 2005–2007 оны үйл ажиллагааны чиглэлийг боловсруулан хэрэгжүүлэх арга хэмжээ авлаа. Үйл ажиллагааны чиглэлд хүүхдэд ээлтэй эрх зүйн шинэтгэл; хүүхдийн эрүүл, аюулгүй орчин; хүүхдийн чанартай боловсрол, төлөвшил; гэр бүл дэх хүүхэд хамгаалал; хүүхдийн оролцоо, мэдээллийн хүртээмж гэсэн үндсэн бүлгийн хүрээнд олон шинэ асуудлыг дэвшүүлэн тавилаа. Өнгөрсөн хоёр жилийн хугацааны ажлын үр дүнг үнэлэх ажлын хэсгийг үндэсний болон орон нутгийн түвшинд байгуулан ажиллаж байна. Хүүхдийн төлөө үндэсний газрын шинэ чиг үүргийг дэмжих, сургалт, мэдээллээр хангах, салбар хоорондын зохицуулалтын талаар тайлангийн 39–46 дугаар заалтад тайлбарласан болно.

**16.** Монгол Улсын Үндсэн хуулийн аравдугаар зүйлд “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ...” гэж заасан байна. Түүнчлэн эдүгээ үйлчилж буй 80 орчим хуульд “дотоодын хууль тогтоомжинд өөрөөр заагаагүй бол олон улсын гэрээ, конвенцийн заалтыг дагаж мөрдөнө” гэж хуульчилжээ.

Олон улсын гэрээний тухай хуульд Улсын Их Хурал нь соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээ болон шаардлагатай гэж үзсэн Монгол Улсын олон улсын аливаа гэрээний хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд Монгол Улсын Засгийн газар өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар байгуулсан олон улсын гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг зохион байгуулахаар заасан байна. Гэхдээ эдгээр хуулийн заалтаас өөр хуулийн тайлбар, удирдамж хараахан байхгүй байна<sup>1</sup>.

**17.** Үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх тухай Палермогийн конвенцид нэгдэх бэлтгэл ажлыг хангаж байна.

---

<sup>1</sup> Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын “Хүний эрх” улирал тутмын сэтгүүл, 2007/ 1, хуудас 3 – 6

18. Хүүхдийн эрхийг хангах, насанд хүрээгүйчүүдийн хорих анги болон цагдан хорих төвд урьдчилан хоригдож байгаа хүүхдийн нөхцөлийг олон улсын хэм хэмжээ, шаардлагад нийцүүлэн шинэчлэх, хуульд заасан эрхийн хэрэгжилтийг судлах, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн яам, НҮБ-ын Хүүхдийн сан хамтран ажиллуулж байна.

19. Хүүхдийн эрхийн тухай конвенц болон бусад нэгдэн орсон олон улсын гэрээний заалтыг аль болох өргөн хүрээнд хэрэглэж хэвших, практик болгох талаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн болон Улсын дээд шүүхийн зөвлөмж, тайлбар, тогтоол гаргах, түүнийг практикт хэрэглэх чадавхийг хөгжүүлэх шаардлага гарч байна. Түүнчлэн хууль эрх зүйн актыг амьдралд хэрэгжүүлэх санхүүгийн хөшүүргийг бүрдүүлэхэд илүүтэй анхаарч ажиллах хэрэгцээ нэмэгдэж байгааг Засгийн газар хүлээн зөвшөөрч байна.

**(12). Олон улсын ба хөгжлийн байгууллага, агентлагаас хүүхдийн төлөө хэрэгжүүлж буй дэмжлэг, туслалцаа, хөтөлбөр**

20. Монгол Улсын Засгийн газар хүүхдийн эрхийн асуудлаар Монгол Улсад өгсөн дүгнэлт зөвлөмжийн 16 дугаар заалтыг дэмжин ажиллаж байна. Монгол Улс хүүхдийн эрхийг хангах чиглэлээр НҮБ-ын төрөлжсөн байгууллага, олон улсын ба бусад орны олон байгууллагатай идэвхитэй хамтран ажиллаж байна.

21. НҮБ-ын төрөлжсөн байгууллага, үүний дотор НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хүн амын сан, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага Хүүхдийн өвчний цогц менежмент; Дархлаажуулалтын өргөжүүлсэн хөтөлбөр; Эмийн эргэлтийн сан; Эсэн мэнд амаржихуй; Эх, хүүхдийн хоол, тэжээл; Өсвөр үеийн эрүүл мэндийн ээлтэй тусламж, үйлчилгээ; Нөхөн үржихүйн эрүүл мэнд зэрэг хөтөлбөр, төслийг эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлж байна. Мөн хэрэглээний усны чанарыг сайжруулах, иод болон бичил бодисын дутлаас эх, хүүхдийг сэргийлэх ажилд ихээхэн хувь нэмэр оруулж байна.

Бага насны хүүхдийн өсөлт хөгжил, Хүүхдэд ээлтэй сургууль, Холимог бүлгийн сургалт, Сурлагын амжилтын судалгаа зэрэг хэрэгжүүлж буй төсөл боловсролын салбарт хүүхдийн эрхийг дээдэлсэн орчин бүрдүүлэх, бүх хүүхдийг тэгш хамран сургах, сургууль завсардалтыг бууруулах, хүүхдийн төлөө олон нийтийн оролцоо түншлэлийг хөгжүүлэх зэрэгт эерэгээр нөлөөлж, хамтын ажиллагааны нааштай үр дүнд хүрч байна. Мөн Хууль зөрчсөн хүүхдийн эрхийн хамгаалал, хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл болон хүүхдийг бэлгийн зорилгоор ашиглах, хил дамнуулан худалдахаас сэргийлэх талаар төрийн болон иргэний нийгмийн байгууллагын хандлага ойлголтыг өөрчлөхөд анхаарч ажиллаж байна.

Нийгмийн цогц суурь үйлчилгээ, онцгой байдал, гамшгийн үед хүүхдэд хүргэх үйлчилгээ зэрэг хөтөлбөр, төсөл хүүхдэд хүргэх үйлчилгээний үр дүнтэй загвар болж чадлаа. Урьд олсон амжилт, туршлагад үндэслэн Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүүхдийн сангийн хооронд 2007–2011 онд хамтран ажиллах хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна.

22. Хүүхдийн эрхийн тухай конвенц болон нэмэлт протоколуудыг хэрэгжүүлэх асуудлаар Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэхийн зэрэгцээ Хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудлаар



Тусгай эрхт төлөөлөгчийг НҮБ–д томилуулах асуудлыг дэмжин ажиллах болно.

**23.** НҮБ–ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага зудад нэрвэгдсэн хүүхдэд тусламж үзүүлэх, бичиг үсгийн тайлагдалтыг нэмэгдүүлэх зэрэг төслийг хэрэгжүүлж байна.

**24.** Олон улсын хөдөлмөрийн байгууллага хүүхдийн хөдөлмөрийг устгах, түүнээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр (АЙПЕК)–ийг 1999 оноос эхлэн АНУ–ын Хөдөлмөрийн департаментын санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн 3 дахь үе шатыг 2005 оноос 2009 оныг хүртэл үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

Хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн хөдөлмөрийн талаарх үндэсний хэмжээний судалгаа явуулах, хүүхдийн хөдөлмөрийн нөхцөл байдалд хяналт–шинжилгээ, үнэлгээ явуулах боломжтой болсон бөгөөд хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар Засгийн газар, эзэд, үйлдвэрчний эвлэлийн болон төрийн бус байгууллагын ажилтнуудын ойлголт, мэдлэг, хандлага сайжирч, улмаар хөдөлмөр эрхэлж буй хүүхэдтэй ажиллах арга зүй хөгжиж, хүүхдийн хөдөлмөрийн талаарх төрийн бодлогыг тодорхойлох, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлд зарим ахиц гарч байна.

**25.** Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын санхүүгийн байгууллагын шугамаар манай улсад хэрэгжүүлж буй төрөл бүрийн хөтөлбөр, төсөл хүүхдийн сайн сайхан байдалд чухал үр нөлөө үзүүлж байна.

**26.** Монгол Улс хүүхдийн эрх ашгийг дээдэлж хоёр болон олон талт хамтын ажиллагаагаа хандивлагч орнууд, эдгээрийн Засгийн газар, олон нийт, төрийн бус байгууллагуудын хүрээнд өргөжүүлж байна. *Тухайлбал,*

Их Британий Хүүхдийг ивээх сан “Боловсрол”, “Хүүхэд хамгаалал” гэсэн хоёр үндсэн хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Боловсролын хөтөлбөрийн хүрээнд сургуулийн өмнөх боловсролын олон хэлбэрийг хөгжүүлэх, боловсролын орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, боловсролын нийгмийн ажилтныг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд анхаарах чиглэлээр Засгийн газрын байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Хүүхэд хамгааллын хөтөлбөрийн хүрээнд хараа хяналтгүй хүүхэдтэй ажилладаг үндэсний байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, бие махбодын шийтгэлээс хамгаалах нөлөөлөл, сургалт, сурталчилгааг өргөжүүлэх, хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог хөгжүүлэхэд хамтран ажиллаж байна.

Дэлхийн зөн Олон улсын байгууллага үндэсний хэмжээнд олон аймаг, орон нутгийг хамруулан (*давхардсан тоогоор*) 1.2 сая хүн, үүний дотор 230000 хүүхдэд байнгын дэмжлэг тусалцаа үзүүлэн ажиллаж байна. Дэлхийн зөн олон улсын байгууллага орон нутгийн хөгжлийн, ерөнхий боловсролыг дэмжих тэтгэлэг, гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх олон нийтэд зориулсан, хүүхдийн оролцооны, өөрийн гэр бүлдээ эргэн нэгдсэн хүүхдийг дэмжих, хүүхдийн эрүүгийн эрх зүй зэрэг хөгжлийн тулгамдсан асуудлын чиглэлээр олон тооны хөтөлбөр, төслийг бүх шатны засаг захиргааны байгууллага, иргэд, хүүхэдтэй хамтран хэрэгжүүлж байна.

Тайваны Засгийн газар, иргэдийн санаачилгаар Монголын хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхэд, гэр бүлийг дэмжих зорилгоор 2006 оноос “Хүүхэд, гэр бүлийг дэмжих сан”

байгуулан жилд дунджаар 200.0 мянган ам долларын мөнгөн тэтгэлэг үзүүлэх зэрэг хэд хэдэн хөтөлбөр хэрэгжүүлж байна.

27. Монгол Улсаас Японд болсон газар хөдлөлт, Зүүн Өмнөд Азийн орнуудад тохиолдсон цунамид нэрвэгдсэн хүмүүст сэтгэл санааны болон эд материалын дэмжлэг, туслалцаа үзүүлсэн байна.

**(13) Хүүхдийн эрхийн наад захын стандартыг хүлээн зөвшөөрсөн, үр нөлөө бүхий бодитой үндэсний хууль тогтоомжийн заалтыг тайлбарлах**

28. Тайлангийн хугацаанд Засгийн газраас шинээр төрсөн хүүхдэд төрсний гэрчилгээг үнэ төлбөргүй олгох, түр болон шинээр суурьшсан иргэдийн иргэний баримт бичгийн зөрчлийг арилгах замаар тэдний нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлж, эх, хүүхэд, гэр бүлд олгох мөнгөн тэтгэмжээр дамжуулан гэр бүлд суурилсан хөгжлийн бодлогыг хэрэгжүүлсэн явдал зохих үр нөлөөгөө үзүүлж байна.

Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 26 дугаар зүйлийн “хүүхэд бүр нийгмийн хангамж”-д хамрагдах эрхийг хүлээн зөвшөөрч, Засгийн газраас “Хүүхдийн мөнгө” хөтөлбөрийг 2005 оны нэгдүгээр сараас эхлэн хэрэгжүүлж байна. “Хүүхдийн мөнгө” хөтөлбөрийн хүрээнд эхний шатанд нэг хүнд ногдох орлого нь амьжиргааны доод түвшингээс бага орлого бүхий өрхийн 0–18 насны хүүхэд бүрт сар тутам 3000 төгрөг олгож байсныг өөрчилж, Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуулиар түүний хамрах хүрээг 2006 оны 7 дугаар сараас өргөжүүлэн өрхийн амьжиргааны түвшинг харгалзахгүйгээр 0–18 насны хүүхэд бүрт сар тутам мөнгөн тэтгэмж олгож байхаар хуульчилсан юм. Энэ хуульд нийцүүлэн Улсын Их Хурлын 2006 оны 47 дугаар тогтоолоор хүүхэд бүрт сар тутам олгох мөнгөн тэтгэмжийг 3000 төгрөг, шинээр төрсөн хүүхдэд олгох мөнгөн тусламжийн хэмжээг 100000 төгрөг, шинээр гэрлэгчдэд олгох мөнгөн тусламжийн хэмжээг 500.000 төгрөг байхаар тогтоосон байна. Мөн эхчүүд жирэмсний таван сартайгаас эхлэн 12 сарын хугацаанд сар тутам тэтгэмж авах, түүнчлэн олон хүүхэд төрүүлж өсгөсөн “Эхийн алдар” нэг, эсхүл хоёрдугаар зэргийн одонтой эх жилд нэг удаа мөнгөн тусламж авах эрхтэй боллоо. Эдгээр тэтгэмж, тусламжийн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 2006 онд (давхардсан тоогоор **1006.8** мянган эх, хүүхдэд **47.1** тэрбум төгрөгийг зарцуулсан бөгөөд 2007 онд хүүхэд, гэр бүлийн хөгжлийг дэмжих арга хэмжээнд улсын төсвөөс **84.3** тэрбум төгрөг, Монгол Улсыг хөгжүүлэх сангаас **114.6** тэрбум төгрөгийг (нийтдээ **198.9** тэрбум төгрөг)-ийг олгохоор хуваарилсан байна.

29. НҮБ-ын Хүүхдийн сангийн Монгол дахь Суурин төлөөлөгчийн газар “Хүүхдийн мөнгө” хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд 2006 оны 4–6 дугаар сард хийсэн судалгааны дүгнэлт, саналаа Засгийн газарт хүргүүлсэн байна. Энэ хөтөлбөр төрийн бус болон шашны байгууллагын зарим асрамжийн газарт байгаа, түүнчлэн гудамжинд амьдарч байгаа, хууль зөрчиж эрх чөлөөгөө хасуулсан хүүхдэд тэр бүр хүрэхгүй байна. Түүнчлэн мөнгөн тэтгэмж, тусламжийн хэмжээ нь дэлхийн зах зээл дэх үнэт металлын ханштай шууд хамааралтай учир үнэт металлын үнэ буурах нөхцөлд тогтоосон хэмжээгээр мөнгөн тэтгэмжийг олгох боломжгүй болох, улс төрийн зэрэг шалтгааны улмаас эх үүсвэрийн түвэгтэй байдалд орох магадлал байна гэж Дэлхийн банк үзсэн байна.

**30.** Монгол Улсын Засгийн газар 2006 оны 7 дугаар сарын 1–ний өдрөөс эхлэн шинэ төрсөн хүүхдийг үнэ төлбөргүй бүртгэн төрсний гэрчилгээ олгох болсон байна. Энэ шийдвэр бол Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 7 дугаар зүйлд заасан “Хүүхэд төрмөгцөө бүртгэгдэх ёстой...” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүллээ. Аймаг, сум, дүүргийн иргэний бүртгэл мэдээллийн байгууллага, ажилтан шинээр төрсөн хүүхэд бүрийг бүртгэн гэрчилгээ олгож байна.

**31.** Шинээр 2007 оны эхний хагас жилд мэндэлж, иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд бүртгэгдсэн 30000 хүүхдийн төрсний гэрчилгээг улсын төсвөөс үнэ төлбөргүй олгосон байна.

**32.** Боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай хуульд дараахь агуулга бүхий заалтыг шинээр нэмж тусгалаа:

- 32.1. Сургалтын орчинд аливаа хэлбэрийн дарамт, хүчирхийлэл болон бие махбод, сэтгэл санааны шийтгэлийг хориглох;
- 32.2. Багш нар мэргэжлийн ёс зүйн дүрэмтэй байх;
- 32.3. Сургуулийн удирдлага, багш нар суралцагчдын эрх, нэр төрийг хүндэтгэх, тэдний хувийн нууцыг задруулахгүй байх, хуульд заагаагүй янз бүрийн төлбөр хураамж авах замаар эдийн засгийн дарамт үзүүлэхгүй, сургалтын материал албадан авахуулахгүй байх;
- 32.4. Бүх хүүхдэд боловсрол эзэмшүүлэх, ялангуяа үндэстний цөөнхийн хүүхдэд сурах орчин бүрдүүлэх талаар орон нутгийн удирдлага болон боловсролын байгууллага тодорхой үүргийг хүлээх;
- 32.5. Боловсролын хөтөлбөр болон агуулга нь жендерийн мэдрэмжтэй байх;
- 32.6. Төрийн өмчит бүх шатны сургуулийн тогтмол зардал, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны нийт зардал, цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын зарим хэсэг, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр ерөнхий боловсролын албан болон албан бус сургалтад хамрагдаж байгаа нэг сурагчид ногдох сургалтын норматив зардлыг улсын төсвөөс тус тус санхүүжүүлэх;
- 32.7. Нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг сургуулийн байршил, хэв шинж, мэргэжлийн чиглэл болон хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээтэй уялдуулан сургалтын байгууллага тус бүрээр ялгавартай тогтоох аргачлалыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлах;
- 32.8. Хуулийн энэхүү заалтыг зөрчсөн тохиолдолд захиргааны болон мөнгөн торгууль ногдуулахаар хуульчилсан байна.

Ийнхүү хуулиар боловсролын байгууллагын орчинд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс хамгаалж байгаа бөгөөд хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар олон нийтийн хандлагыг өөрчлөхөд нэг чухал алхам боллоо.

**33.** Асуудлыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих өргөн хүрээнд хүүхэд, өсвөр үеийнхний иргэний оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар “Нийгмийн хөгжилд хүүхэд, өсвөр үеийнхний оролцоог дэмжих төрийн бодлого” баримт бичгийн төслийг санаачлан боловсруулж, УИХ–д хэлэлцүүлэхээр өргөн бариад байна.

**(14) Хүүхдийн эрхийг хамгаалах үйл ажиллагааны зохицуулалт, хяналт**

**34.** Монгол Улсын Засгийн газрын нийтлэг бүрэн эрхийн хүрээнд хүүхдийн эрхийг хамгаалах төрийн бодлого боловсруулах, хүүхдийн эрхтэй холбоотой хууль тогтоомжийн биелэлтийг хангах, хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэг хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудлыг Засгийн газрын гишүүн Монгол Улсын Шадар сайд эрхэлж, түүний удирдлагад Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхдийн төлөө үндэсний газрыг ажиллуулж байна.

Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт хүүхдийн асуудлаар төрийн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих чиг үүргийг тухайн шатны Засаг дарга нар хүлээдэг. Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд хэрэгжүүлэгч агентлаг Хүүхдийн төлөө төв мэргэжлийн үйл ажиллагаа явуулж байна.

Сумын түвшинд Засаг даргын Тамгын газарт хүүхдийн эрхийн асуудал хариуцсан мэргэжилтэн бүтэн орон тоогоор ажиллаж чадахгүй байна. Харин нийслэлийн хороод болон хот, хөдөөгийн ерөнхий боловсролын сургуульд нийгмийн ажилтан орон тоогоор ажиллаж байна.

**35.** Хүүхдийн төлөө үндэсний газар Засгийн газрын бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хүүхдийн эрхийг хамгаалах асуудлаар салбар хоорондын зохицуулалтын ажлыг эрхлэхээс гадна хүүхдийн хөгжил, хамгааллын чиг үүрэг бүхий төрийн төв, орон нутгийн байгууллагад мэргэжлийн зөвлөгөө өгөх, арга зүйн дэмжлэг үзүүлэх үүргийг хүлээж байна. Энэ газрын чиг үүргийг холбогдох хууль тогтоомж болон байгууллагын стратегийн баримт бичигт дараах байдлаар тодорхойлсон байна:

Хүүхдийн эрхийн тухай конвенц, үндэсний бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх төр, засгийн болон төрийн бус зэрэг байгууллагын чадавхи бүрдүүлэхэд чиглэсэн мэдээлэл, мэргэжлийн арга зүйгээр хангах;

Хүүхдийн эрхийн тухай конвенцийн зарчимд тулгуурлан үндэсний хэмжээний бодлого, шийдвэрийг боловсруулах, улмаар Хүүхдийн эрхийн тухай конвенц, үндэсний бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хүүхэдтэй холбогдсон бодлого, үйл ажиллагаа эрхэлдэг бүхий л байгууллагад нөлөөлөх;

Хүүхдийн өөрсдийн нь оролцоог идэвхжүүлэх, тэднийг хэрэгцээтэй мэдээллээр хангах, чадвар суулгах замаар хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагыг чадавхжуулж, бодлого, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;

Иргэний нийгмийг идэвхжүүлэх, хүүхдүүд өөрсдийгөө удирдан зохион байгуулж, ирээдүйн амьдралынхаа бүхий л хүрээнд тэгш оролцох бололцоо, нөхцөл бүрдүүлэх талаар мэдлэг, дадлага олгох;

Олон улс, үндэсний болон орон нутгийн түвшинд үйл ажиллагаа явуулж буй хүүхдийн болон насанд хүрэгчдийн холбогдох байгууллагыг мэдээлэл харилцааны хэрэгслээр дамжуулан зохих мэдээллээр хангах зэрэг монгол орны хүүхдийн өнөөгийн болоод ирээдүйн эрх ашигт нэн тэргүүнд үйлчлэх болно.

**36.** Хүүхдийн төлөө үндэсний газар 2006 онд “Өсвөр үе, залуучуудын хөгжил” үндэсний чуулган, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлаарх “Хамтдаа хөгжицгөөе” үндэсний чуулганыг хүүхдийн оролцоотойгоор зохион байгууллаа. “Өсвөр үе, залуучуудын хөгжил” үндэсний чуулганаар Төрөөс өсвөр үе, залуучуудын хөгжлийн

талаар баримтлах бодлогын, “Хамтдаа хөгжицгөө” чуулганаар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар явуулах бодлогын баримт бичгийн төслийг хэлэлцүүлсэн байна.

Мөн Сургуулийн нийгмийн ажилтны нийгэмлэг, Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрхийн үндэсний төв, Залуучуудын улаан загалмай нийгэмлэг зэрэг цөөвөр төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж байна.

**37.** Хүүхдийн төлөө үндэсний газар хүүхдийн чиглэлээр ажилладаг мэргэжлийн байгууллага, хүмүүс (шүүгч, хуульч, өмгөөлөгч, нийгмийн ажилтан, эмч, сэтгүүлч болон салбарын удирдах ажилтан)-ийг сонгон хүүхдэд ээлтэй хууль эрх зүйн орчин бүрдүүлэх, хууль зөрчсөн хүүхдийн эрхийг хамгаалах, нөхөн сэргээх, нийгэмшүүлэх үйл ажиллагаатай танилцуулах зэргээр төвлөрсөн, бүсчилсэн, зайны, ажлын байран дахь хэлбэрээр олон төрлийн сургалтыг НҮБ-ын Хүүхдийн сан, Их Британий Хүүхдийг ивээх сан, Дэлхийн зөн зэрэг байгууллагын санхүүгийн болон техникийн дэмжлэгээр тогтмол зохион байгуулж байна.

**38.** Монгол Улсын Засгийн газраас 2004–2006 онд хүүхдийн хөгжил, хамгааллын салбар дундын зохицуулалтын ажилд 60 гаруй сая төгрөгийг хуваарилсан байна.

**39.** Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн цар хүрээтэй уялдан Хүүхдийн төлөө үндэсний газрын салбар дундын зохицуулалтын чиг үүрэг, салбарын бодлого, үйл ажиллагаанд хүүхдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн үндэсний чадавхийг бүрдүүлэх хэрэгцээ, шаардлага улам өсөн нэмэгдэж байна. Үүнтэй холбогдуулан Хүүхдийн төлөө үндэсний газрын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн эрх дархыг Засгийн газрын тохируулагч агентлаг болгон өргөтгөх, улмаар Хүүхдийн төлөө үндэсний газрын хүүхдийн хөгжил, хамгааллын салбар хоорондын зохицуулалтын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэлийг холбогдох хууль эрх зүйн баримт бичигт нарийвчилан тусгах шаардлагатай байна.

Мөн Хүүхдийн төлөө үндэсний газар, орон нутгийн хүүхдийн төлөө байгууллагын удирдлагыг бэхжүүлэх, ажилтны ур чадварыг хөгжүүлэх, түүнд шаардагдах хөрөнгийн хэмжээ болон техник хэрэгслийн хангамжийг зайлшгүй нэмэгдүүлэх хэрэгтэй байна. Төрөөс хүүхдийн талаар баримтлах бодлогыг сум, дүүргийн түвшинд хэрэгжүүлэх хүүхдийн төлөө алба байгуулах, түүний боловсон хүчний хүртээмж, ур чадварыг сайжруулах хэрэгцээ гарч байна.

**40.** Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд тэргүүлдэг бөгөөд энэхүү зөвлөл хүүхдийг хөгжүүлэх, хамгаалахтай холбогдсон төрийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд нийгмийн нөөц баялгийг дайчлах, төр, олон нийтийн болон бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг оролцуулах үйл ажиллагааг зохицуулан зохион байгуулах чиг үүрэгтэй ажиллаж байна. Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн ажлын албаны үүргийг эдүгээ Хүүхдийн төлөө үндэсний газар гүйцэтгэдэг юм.

Монгол Улсын Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл дараах үндсэн үүргийг хэрэгжүүлж байна:

- (1) хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газарт болон холбогдох бусад байгууллагад зөвлөх, хүүхэд хөгжүүлэх, хамгаалах үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааг зохицуулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

- (2) хүүхдийн эрхийг хамгаалах асуудлаар холбогдох байгууллага, албан тушаалтны тайлан, мэдээллийг сонсох, энэ талаар цаашид авах арга хэмжээний тухай саналаа Засгийн газар, холбогдох бусад байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх;
- (3) хүүхдийн эрхийг хамгаалах асуудлыг шийдвэрлэхэд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг оролцуулах, тэдгээрийн гаргасан санал, санаачилгыг дэмжих;
- (4) хүүхдийн эрхийг хамгаалах үйлсэд идэвх зүтгэл гаргаж, гавьяа байгуулсан хүүхэд, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг шагнах, урамшуулах тухай саналаа холбогдох байгууллага, албан тушаалтанд тавих;
- (5) хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах асуудлаар бусад улс, тэдгээрийн төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагатай хамтран ажиллах;
- (6) хууль тогтоомжид заасан бусад үүргийг хүлээж ажиллаж байна.

**41.** Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга нар Монгол Улсын Шадар сайдтай хүүхдийн хөгжил, хамгааллын асуудлаар бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээг жил бүр байгуулдаг төдийгүй аймаг, нийслэлийн Засаг дарга хүүхдийн төлөө төвийн даргатай үр дүнгийн гэрээг байгуулан ажиллаж байна. Түүнчлэн сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд Хүүхдийн төлөө зөвлөл ажиллаж байна.

**42.** Цаашид бүх түвшний хүүхдийн төлөө зөвлөлийн шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх, хянах арга хэрэгслийг боловсронгуй болгох замаар хүүхдийн төлөө зөвлөлийн ажлын үр нөлөөг сайжруулах явдал хурцаар тавигдаж байна.

**43.** Хүүхдийн эрхийг хангахад бүх салбарын идэвхтэй хамтын ажиллагааг хөгжүүлэхийг хүүхдийн эрх ашиг шаардаж байна. Энэ шаардлагын үүднээс хүүхдийн асуудлаар бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд олон нийт, хүүхэд, өсвөр үеийнхний санал бодлыг дэмжин ажиллах лобби бүлгийг УИХ-ын 12 гишүүний санаачилгаар УИХ-д байгуулан ажиллаж байна.

УИХ-ын лобби бүлэг нь УИХ-аас гарч буй эрх зүйн болон бодлогын баримт бичгүүдэд хүүхдийн эрхийг хамгаалах аливаа асуудлыг тусгуулах, Хүүхдийн эрхийн тухай конвенцийн зарчимд нийцүүлэн үндэсний хууль тогтоомжийг шинэчлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллаж байна. Энэ хүрээнд УИХ-ын лобби бүлэг УИХ-д хүүхдийн асуудал хариуцсан дэд хороо байгуулах боломжийг судалж байна.

### **(15) Хүүхдийн эрх зөрчигдсөн үед хүүхдийн эрхийг хянах үндэсний болон орон нутгийн түвшний арга хэрэгсэл, тогтолцоо**

**44.** Хүүхдийн эрхийн хорооноос Монгол Улсад өгсөн дүгнэлт, зөвлөмжийн 14 дүгээр заалтыг дэмжин ажиллаж байна. Монгол Улсын Их Хурал Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг 2003 онд баталсан бөгөөд энэхүү хөтөлбөрт төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангах баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх тууштай, үр дүнтэй хэрэгжүүлэхэд төрийн ба төрийн бус байгууллага, иргэд, орон нутгийн өөрөө удирдах байгууллага, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, хувийн хэвшлийн оролцоог өргөтгөх заалтыг багтаасан байна (хөтөлбөрийн англи орчуулгыг хавсаргав).

Хүний эрхийн Үндэсний Комиссын жил бүрийн тайлан илтгэлийг хүний эрхтэй холбоотой тодорхой үндсэн асуудлаар бэлтгэн нийтлүүлж байгаа бөгөөд энэ хүрээнд хүүхдийн эрхийн асуудлыг тусгаж байна. *Тухайлбал*, Хүний эрхийн Үндэсний Комиссын 2004 оны тайланд үндэсний цөөнх хүүхдийн эрх ашгийн асуудал, 2005 оны тайланд зохистой хооллолт, 2006 оны тайланд эрүүдэн шүүх үйл ажиллагааны талаар танилцуулсан байна.

**45.** Хүний эрхийн Үндэсний Комисс, Хүүхдийн төлөө үндэсний газар хамтран “Хүүхдийн элчийг шалгаруулах журам”-ыг боловсруулан гаргаж, аймаг, нийслэл, сумын түвшинд хүүхдийн элчээр 150 хүнийг сонгон шалгаруулах замаар ажиллуулж байна. Энэ бол манай орны тухайд омбудсманы нэг хэлбэр юм.

Хүүхдийн элч нарыг хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын чиглэлээр мэргэшүүлэх, хүүхдийн эрхийн зөрчилд хяналт тавих, түүнийг судлах, танилцуулах, мэдээлэх арга зүйд сургах ажлыг үе шаттай зохион байгуулж байна. *Тухайлбал*, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйд аймаг, сумын хүүхдийн элч, хүүхдийн төлөө төвийн арга зүйч нарыг сургасан байна. Гэвч хүүхдийн элчийн үйл ажиллагаа хот, хөдөөд эхлэлийн төдий байгааг хүлээн зөвшөөрч байна.

**46.** Авлигын эсрэг хууль (2006) болон Авлигалтай тэмцэх үндэсний хөтөлбөр (2002)- ийг УИХ-аар батлуулан хэрэгжүүлж байна. Авлигатай тэмцэх газрыг 2006 онд зохион байгуулан ажиллуулж, авлигын талаар үндэсний хэмжээнд ухуулан таниулж ойлгуулах, төрийн байгууллагын авлигын талаарх мэдээллийг цуглуулах үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллаж байна.

Авлигатай тэмцэх албыг тусгайлан байгуулснаар хүүхдэд үйлчилдэг бүх шатны төрийн байгууллагын хүнд суртал, авлига, хээл хахуулийн үйл ажиллагааг таслан зогсоох, улмаар бүрэн арилгах уур амьсгалыг нийгэм, хамт олны дунд бүрдүүлнэ гэж Засгийн газар үзэж байна.

**47.** Нээлттэй засаглал, цахим засаглалыг хөгжүүлэх зорилгоор “Цахим монгол” хөтөлбөрийн хүрээнд төрийн мэдээллийн сүлжээг байгуулан найдвартай ажиллагааг ханган ажиллаж байна. Монгол Улсын төсвийн талаарх мэдээллийг [www.iltod.gov.mn](http://www.iltod.gov.mn) вэб сайтад байршуулан төсвийн төлөвлөгөөний төсөл, төсвийн зарцуулалтын гүйцэтгэл, төсвийн өр, авлагын мэдээллийг сар, улирлаар олон нийтэд нээлттэй, ил тод танилцуулдаг боллоо.

### **(18) Конвенцийн хэрэгжилтэд холбогдох талуудын оролцоог хангасан байдал**

**48.** Монгол Улсын Засгийн газар, Хүүхдийн төлөө үндэсний газар хамтран “НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга зам” сэдэвт үндэсний хэлэлцүүлгийг 2005 оны 9–12 дугаар саруудад орон даяар явуулж, түүнд төв, орон нутгийн төлөөлөл бүхий 5000 гаруй иргэд, хүүхдийг хамруулав. Улмаар хэлэлцүүлгийн нэгдсэн дүнг шүүн хэлэлцэх Үндэсний дээд хэмжээний бага хурлыг Хүний эрхийн Үндэсний Комисс, салбарын яамдын болон орон нутгийн удирдлага, хүүхдийн төлөө ажилладаг төрийн бус байгууллага, хүүхдийн төлөөллийг оролцуулан зохион байгуулав. Үндэсний дээд хэмжээний бага хурлаар зөвшилцсөн арга хэмжээг Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хоёр дахь шатны үйл ажиллагааны чиглэлд тусган хэрэгжүүлж байна.

49. Хүүхэд, гэр бүлд түшиглэсэн нийгмийн үйлчилгээг төв, суурин газруудад төрийн бус байгууллага, хамт олноор гэрээлэн гүйцэтгүүлэх хэлбэр нэлээд хөгжиж байна. Ойрын жилүүдэд гэрээгээр гүйцэтгүүлэх үйлчилгээний нэр төрөл, ажлын цар хүрээ, санхүүжилтийг нэмэгдүүлэх, ялангуяа хөдөөд олон нийтийн оролцоо бүхий нийгмийн үйлчилгээний тогтолцоог өргөжүүлэн хөгжүүлэх шаардлагатай байна. Нийгмийн халамжийн хууль тогтоомжийн хүрээнд улсын хэмжээнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх үйл ажиллагааны талаарх мэдээллийг нэгтгэх, дүгнэх тогтолцоо үгүйлэгдэж байна.

50. Жил бүрийн зургаадугаар сарын нэгний өдрийг “Хүүхдийн баяр”-ын буюу хүүхдийн эрхийг хамгаалах бүх нийтээр амрах баярын өдөр болгон хуульчилсан бөгөөд энэ өдөр төрийн болон хувийн хэвшлийн бүх аж ахуйн нэгж, байгууллагууд хүүхдийн төлөө гүйцэтгэсэн ажлаа дүгнэж, хүүхдэд зориулсан өдөрлөг, уралдаан тэмцээнийг зохион байгуулан ажиллаж байна. Энэ өдөр хүүхдийн эрхийг хүндэтгэх, түүнийг олон нийтэд таниулан ойлгуулах, сурталчилах үйл ажиллагааг өргөн хэмжээнд явуулдаг.

Сүүлийн үед бизнесийн байгууллагуудын зүгээс хүүхдийн төлөөх үйл ажиллагааны хөрөнгө оруулалт нэмэгдэж байна. *Тухайлбал*, Мобиком ХХК 2006 оны хичээлийн жилээс хэрэгжүүлж эхэлсэн ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын “Үдийн цай” хөтөлбөрийг туршин арван тэрбум төгрөг зарцуулсан, ХАС банк “Хүүхдийн хадгаламж” нээж ажиллуулах, Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр дэргэдээ “Энэрэл” халамжийн байгууллагыг ажиллуулж байгаа зэрэг олон сайн туршлагыг нэрлэж болно.

51. НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран Монгол Улсын Боловсролын их сургууль “Хүүхдийн эрхийн боловсролын төв”-ийг 2005 онд байгуулан ажиллуулж байна. Энэ төв багш, оюутанд зориулсан “Хүүхдийн эрхийн боловсролын сургалтын модуль”-ийг боловсруулан туршсан байна. Сургуулийн орчинд хүүхэд ямар нэгэн дарамт шахалтгүйгээр сурах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн нийт 70 гаруй сургалтад 4000 гаруй багш нарыг хамрууллаа.

52. Хүүхдийн эрхийн конвенцийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд бүх талын оролцоог хангах, хамтран ажиллахад анхаарч байгаа боловч олон нийтийн хандлагыг өөрчлөх, хүүхдийн эрхийг нийгмийн бүхий л хүрээнд хүлээн зөвшөөрөх явдал тулгамдсан асуудал хэвээр байна. Иймд хүүхдийн асуудал хариуцсан төрийн болон иргэний байгууллагуудын хандлагыг өөрчлөх, ур чадварыг нэмэгдүүлэх, нийгмийн ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хүүхдийн төлөө зарцуулах төсөв хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэхэд анхаарч ажиллах болно.

**(17) Конвенцийг олон нийтэд таниулан сурталчилсан байдал, ялангуяа өмнөх тайлан, түүнд өгсөн хорооны дүгнэлт, зөвлөмжийг үндэсний цөөнхийн хэлээр орчуулж, танилцуулсан байдал**

53. Монгол Улс хүүхдийн эрхийн асуудлаар Монгол Улсад өгсөн дүгнэлт, зөвлөмжийн 21 дүгээр заалтыг хэрэгжүүлэхээр конвенцийн агуулга, зарчмыг нийгмийн бүх давхарга, бүс нутагт хүргэх үйл ажиллагааг олон хэлбэрээр өрнүүлж байна. Тайлангийн хугацаанд НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны 39 дүгээр чуулганаас Монгол Улсад өгсөн дүгнэлт, зөвлөмж, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын явуулсан



Хүүхдийн эсрэг хүчирхийллийн судалгаа, түүний хүүхдэд зориулсан хувилбар зэрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцийг сурталчилсан 50 гаруй төрлийн ном, товхимолыг монгол хэлээр хэвлэн гаргасан байна.

**54.** Хүүхдийн төлөө үндэсний газрын дэргэд Хүүхдийн эрхийн асуудлаар мэргэшсэн хэвлэл мэдээллийн ажилтны багийг 2005 оноос байгуулан ажиллуулж байна. Их Британий Хүүхдийг ивээх сан, Дэлхийн зөн олон улсын байгууллага болон бусад түншлэгч талуудтай хамтран хэвлэл мэдээллийн ажилтны багийн чадавхийг хөгжүүлэх чиглэлийн сургалтыг тогтмол зохион байгуулж ирлээ. Хэвлэл мэдээллийн ажилтны багийн гишүүд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, өдөр тутмын сонин хэвлэлээр хүүхдийн эрхийн хялбаршуулсан танилцуулга, зар сурталчилгааг бэлтгэн явуулдаг. Эдгээр үйл ажиллагааны дүнд хүүхдийн эрхийн талаарх олон нийт, хүүхдийн ойлголт нэмэгдэж, хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн үйл ажиллагаа өргөжиж байна.

**55.** Түншлэгч талуудтай хамтран Хүүхдийн эрхийн тухай конвенцийг хүүхдэд ойлгомжтой, зураг чимэглэл бүхий хэлбэрээр зохиомжлон хэвлүүлсний зэрэгцээ Хүүхдийн эрхийн тухай конвенцийг казах хэлэнд хөрвүүлэн хэвлүүлж гаргасан байна. Конвенцтой холбоотой мэдээллийн тогтолцоо

**56.** Монгол Улсын Засгийн газар хүүхдийн эрхийн асуудлаар Монгол Улсад өгсөн дүгнэлт, зөвлөмжийн 18 дугаар заалтын хэрэгжилтийн явц эхлэлийн түвшинд байгааг хүлээн зөвшөөрч байна. Энэ чиглэлээр төрөөс хэрэгжүүлж байгаа арга хэмжээний бодит үр дүнг ойрын үед гарна гэж найдаж байна.

**57.** Төрийн мэдээллийн төв байгуулах болон төрийн байгууллагуудын цахим порталын төслүүд амжилттай хэрэгжиж байна.

**58.** Мэдээ баримтын цуглуулалтыг боловсронгуй болгох ажилд НҮБ-ын Хүүхдийн сангийн техникийн тусламжтайгаар Хүүхдийн төлөө үндэсний газар, Үндэсний статистикийн газар хамтран жижиг төсөл хэрэгжүүлж, түүний шугамаар 18 хүртэл насны бүх хүүхдийг хамарсан үндэсний хэмжээний статистик мэдээг цэгцтэй цуглуулахад шаардлагатай шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулж байна.

Энэ ажлын хүрээнд хүүхдийн, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд; ядуу, нэн ядуу амьдарч байгаа хүүхэд; хөдөө амьдарч байгаа хүүхэд; шилжин суурьшсан хүүхэд; хараа хяналтгүй хүүхэд; хууль зөрчсөн хүүхэд; үндэсний цөөнхийн хүүхэд зэрэг эмзэг бүлгийн, хүнд нөхцөлд байгаа хүүхдийн талаарх мэдээг цэгцтэй цуглуулах боломжийг бүрдүүлж, улмаар хүүхдийн асуудлаар үндэсний хэмжээний мэдээллийн сан бүрдүүлэх алхам болно гэдэгт бид итгэлтэй байна.

Төслийн хүрээнд хүүхдийн эмзэг байдлыг тайлбарласан нэгдсэн стандарт ойлголтыг жигдэлж, сургалт зохион байгуулж, мэдээлэл цуглуулах гарын авлагыг энэ ажилд оролцох хүмүүст хүргэх юм.

**59.** Хүүхдийн талаарх олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгааг Үндэсний статистикийн газар таван жилийн давтамжтайгаар 2000, 2005 онд хийгээд байна. Бага насны хүүхдийн хөгжлийн цогц бодлого, хүүхэд залуучуудын оролцооны талаарх салбар дундын бодлогын баримт бичгүүдийг хамтран боловсруулж хэрэгжүүлж байна. Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд үнэлгээ явуулах ажлыг НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран 2007 онд зохион байгуулж байна.

**60.** Үндэсний статистикийн газрын болон төрийн байгууллагуудын хүүхдийн талаарх мэдээллийг боловсронгуй болгох шаардлагатай байна. Тухайлбал, эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын салбарт статистик мэдээллийг 18 хүртэлх насаар ангилан гаргадаггүй, хүнд нөхцөлд байгаа хүүхдийн талаарх нэгдсэн мэдээллийг төрийн захиргааны төв байгууллага хариуцан нэгтгэдэггүй байна.

Хүүхэд хамгааллын төвлөрсөн бус тогтолцооноос хамааран хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн сүлжээ бүрдээгүй байна. Хүүхэд хамгааллын зарим статистик мэдээллийг цуглуулах, боловсруулахад хүндрэлтэй тал байна.

### **Хоёрдугаар бүлэг. Хүүхэд хэмээх тодорхойлолт**

*(1 дүгээр зүйл)*

**61.** Хүүхэд хэмээх ойлголтын тодорхойлолтыг үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулсан мэдээллийг Монгол Улсын үндэсний хоёрдугаар илтгэлийн гуравдугаар бүлэгт буюу 11–15 дахь талд танилцуулсан болно. Монгол Улсын түрүүчийн тайланд дэлгэрэнгүй тусгагдаагүй хуулийн зарим заалтыг тайлбарлаж байна.

**62.** Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль хүүхдийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэл хамгаалахад үйлчилнэ. Энэ хууль Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүүхдэд нэгэн адил хамаарна.

**63.** Монгол Улсын Иргэний хуулийн 14 дүгээр зүйлд “иргэний эрх зүйн чадвар нь иргэнийг төрсөн үеэс эхэлж нас барснаар дуусгавар болно”, “иргэний эрх зүйн чадварыг хязгаарлахыг хориглоно” гэж заасан байна.

Мөн хуулийн 15 дугаар зүйлд иргэний эрх зүйн бүрэн чадамж буюу иргэн өөрийн үйлдлээр өөртөө эрх олж авах, үүрэг бий болгох чадвар насанд хүрснээр буюу 18 наснаас бий болно. Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүх 16–гаас 18 хүртэлх насны иргэнийг, түүний хүсэлт, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр иргэний эрх зүйн бүрэн чадамжтай гэж тооцож болно.

Мөн хуулийн 16 дугаар зүйлд насанд хүрээгүй буюу 14–өөс 18 хүртэлх насны этгээд иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай байна. Мөн хуулийн 17 дугаар зүйлд 7–гоос 14 хүртэлх насны этгээд иргэний эрх зүйн зарим чадамжтай байна. Харин 7 хүртэлх насны этгээд иргэний эрх зүйн чадамжгүй байна.

Мөн хуулийн 18 дугаар зүйлд сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон этгээдийг шүүх иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцож, түүнд асран хамгаалалт тогтооно. Иргэний эрх зүйн чадамжгүй этгээдийн нэрийн өмнөөс түүний хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх, асран хамгаалагч) хэлцэл хийхээр хуульчилсан байна.

**64.** Эрүүгийн хуулийн 21 дүгээр зүйлд гэмт хэрэг үйлдэх үедээ арван зургаан насанд хүрсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх ба арван дөрвөөс арван зургаа хүртэл насны этгээд энэ хуулийн тусгай ангийн 91 (Хүнийг санаатай алах), 96 (Бусдын бие махбодод хүнд гэмтэл санаатай учруулах), 126 (Хүчиндэх), 145 (Бусдын эд хөрөнгийг хулгайлах), 146 (Бусдын эд хөрөнгийг булаах), 147 (Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх), 153 (Бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах, гэмтээх), 181.2, 181.3 (Хүндрүүлэх

нөхцөл байдалтай танхайрах)–т заасан гэмт хэрэг үйлдсэн бол түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байна.

**65.** Гэр бүлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад насанд хүрээгүй этгээдтэй гэр бүл болохыг хориглосон боловч мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт иргэний хуульд заасны дагуу насанд хүрээгүй хүнийг иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжтай гэж зарласан нөхцөлд хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт үл хамаарахаар заасан байна.

**66.** Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлд зааснаар 16 насанд хүрсэн хүн хөдөлмөрийн гэрээ байгуулах эрхтэй бөгөөд энэ зүйлийн 109.5–д (насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтад) харшлахгүй бол 15 насанд хүрсэн хүн эцэг, эх буюу харгалзан дэмжигчийн зөвшөөрөлтэйгээр, мөн мэргэжлийн баримжаа, ажлын дадлага олгох зорилгоор 14 насанд хүрсэн хүнтэй эцэг эх, асран хамгаалагч болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгээр хөдөлмөрийн гэрээ байгуулж болохоор заажээ.

Насанд хүрээгүй хүнийг оюун ухааны хөгжил, эрүүл мэндэд нь харшлах хөдөлмөр эрхлүүлэхийг хориглосон бөгөөд насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар хуульчилсан байна.

**67.** Хүүхдийн эрх үндэстний цөөнхийн амьдралын орчин, нөхцөлийн байдал, гэр бүлийн эмзэг, ядуу байдал, хараа хяналтгүй байдал, гэр бүл дэх болон бусад хүчирхийллийн хэлбэрүүдийн сөрөг үр дагаврын улмаас зарим талаар зөрчигдөж байна.

### **Гуравдугаар бүлэг . Ерөнхий зарчим**

*(2, 3, 6 ба 12 дугаар зүйл)*

**68.** Хүүхдийн эрхийн ерөнхий зарчмуудыг үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулсан мэдээллийг Монгол Улсын үндэсний хоёрдугаар илтгэлийн гуравдугаар бүлэгт буюу 11–15 дахь талд оруулсан болно.

А. Хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй, алагчилахгүй байх

**69.** Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн зөвлөмжийн 23, 24 ба 40 дугаар заалтын хүрээнд нийгмийн эмзэг бүлгийн хүүхдийг ялгаварлан гадуурхагдахаас хамгаалах чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

**70.** Боловсролын тухай хуульд “Монгол Улсын иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана”, “суралцагчдыг ялгаварлан гадуурхахгүй байх” гэсэн заалтыг 2006 онд нэмж оруулсан байна. Хуулийн энэ заалтыг хэрэгжүүлэх чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагаа, төсөв хөрөнгийн асуудлаар долоодугаар бүлэгт дэлгэрэнгүй танилцуулсан болно.

**71.** Хөдөө амьдарч байгаа болон нийслэлд шилжин суурьшиж байгаа хүүхдүүд боловсролын үйлчилгээнд бүрэн хамрагдаж чадахгүй байгаа шалтгааны нэг бол

ялангуяа нийслэл хотод боловсролын байгууллагын хүчин чадал хүрэлцэхгүй байдал үргэлжилж байна. Монгол Улсын Засгийн газар цэцэрлэг, сургуулийн барилга шинээр барих, өргөтгөх, засварлах ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалт болон гадаадын зээл, тусламжаар гүйцэтгэх ажлыг жил бүр зохион байгуулж байна.

Зөвхөн 2006 онд нийт 7052 хүүхдийн суудал бүхий 17 сургууль, 590 хүүхэд хүмүүжүүлэх хүчин чадал бүхий 5 цэцэрлэг, 130 хүүхдийн хүчин чадал бүхий сургуулийн дотуур байрыг шинээр ашиглалтад оруулсны хамт 118 сургууль, цэцэрлэг, дотуур байрны барилгыг засварлалаа.

**72.** Боловсролын байгууллагуудын хүчин чадлыг өргөтгөх, сургалтын орчныг сайжруулах чиглэлээр боловсролын салбарт 2005 онд улсын төсвөөр 7 тэрбум төгрөгийн, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 10.9 тэрбум төгрөгийн; 2006 онд улсын төсвийн болон гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр **9.2** тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

**73.** Монгол Улсын боловсролыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд боловсролын байгууллагын хүчин чадлын хэрэгцээг тодорхойлох замаар 2006–2015 онуудад цэцэрлэгийн хүчин чадлыг 7.8 мянгаар, ерөнхий боловсролын сургуулийн суудлын тоог 69.6 мянгаар, дотуур байрны тоог 5.0 мянгаар, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн суудлын тоог 3.8 мянгаар тус тус нэмэгдүүлэхээр тооцон тусгасан байна.

**74.** Засгийн газраас Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөрийг 2006 онд баталсан бөгөөд эдгээр баримт бичигт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нийгмийн амьдралд оролцох, нийгмийн суурь үйлчилгээг тэгш хүртэхэд ялгаварлан гадуурхахгүй, алагчилахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээг тусгасан байна.

**75.** Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг боловсруулан гаргасан бөгөөд түүнд эмнэлгийн мэргэжилтэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг улс төрийн үзэл бодол, шашин шүтлэг, яс үндэс, хөрөнгө чинээгээр үл ялгаварлан тэгш хүртээмжтэй үзүүлэхээр заасан байна. Харин эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг сурталчлах, хэрэгжүүлэх, хяналт тавихад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, эмнэлгийн ажилтны мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг чиглүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

**76.** Монгол Улсад амьдарч байгаа цөөнх үндэстний хүүхдүүд эх хэлээрээ суралцах боломжийг хангахаас гадна Монгол Улсын төрийн албан ёсны хэлийг сургах асуудал чухал байна. Цөөнхийн хүүхэд төрийн албан ёсны хэлийг хангалтгүй эзэмшсэнээс зарим тохиолдолд гадуурхагдах, тэгш эрхтэй оролцох боломж хязгаарлагдах явдал гарч байна. Үндэсний цөөнхийн хүүхдийн боловсрол эзэмших тэгш боломжийг хангах зорилгоор Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Их Британий Хүүхдийг ивээх сантай хамтран “Казах хүүхдийн боловсролыг дэмжих хөтөлбөр”-ийг боловсруулж, улмаар түүний хэлэлцүүлэг зохион байгуулан хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.

**77.** Хүүхдийн сурлагын амжилтаар багш нарын ажлын чанарыг үнэлэх тогтолцоо үйлчилж буй нөхцөлд хотын сургуулийн багш нар хөдөөгөөс шилжин ирсэн бөгөөд сурлагаар хоцрогдсон хүүхдийг ялгаварлан хандахад хүргэж хүүхэд сургуулиа орхиход нөлөөлж байгаа учраас багшийн ажлын чанарын үнэлгээг өөрчлөх шаардлагатай байна.

Мөн багш нар хотод шилжиж ирсэн сурагчийг гадуурхахгүйгээр дэмжин хөгжүүлэх хөдөлгөөн өрнүүлэх чиглэлээр төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах хэрэгцээ байна.

**78.** Хүүхдийн эрхийг хамгаалахад оролцогч талуудын эерэг хандлага, эцэг эх, асран хамгаалагч байх хариуцлагыг нэмэгдүүлэх асуудал чухал хэвээр байна. Эцэг эх, асран хамгаалагчийн хүүхдэд хандах ёс суртахуун, хариуцлагаас улбаалан гар аргаар алт олборлодог орон нутагт амьдардаг айлын болон хөдөөгийн малчин өрхийн бага насны хүүхэд эрүүл мэнд, боловсролын суурь үйлчилгээнд хамрагдах боломж хязгаарагдмал хэвээр байна. Монгол Улсад хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй, алагчилахгүй байх хууль эрх зүйн ерөнхий зохицуулалт байгаа боловч хүнд нөхцөлд байгаа хүүхдэд хуулийн тодорхой зохицуулалт хангалттай үйлчлэхгүй байна.

### **Б. Хүүхдийн ашиг сонирхлыг дээдлэх (3, 12 дугаар зүйл)**

**79.** Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлийн 11–т гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаалахаар хуульчилсан билээ. Энэ заалтыг Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулиар төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулахдаа хүүхдийн эрх ашгийг эн тэргүүнд хангахыг эрхэмлэх, мөн хүүхэд оюун ухаан, авьяас билэг, бие бялдар, ур чадвараа хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг авах эрхтэй хэмээн баталгаажуулж өгсөн болно. Мөн Гэр бүлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх заалтад “Хүүхэд гэр бүлийн дотор тэгш эрх эдэлнэ” гэж заасан байна.

**80.** Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 7 дугаар заалтад гэр бүл цуцлах нөхцөлд “хүүхэд долоо ба түүнээс дээш настай бол асрамжийн асуудлыг шийдвэрлэхэд түүний саналыг харгалзан үзнэ” гэж заажээ.

Гэр бүлийн тухай хуулиар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, гэрлэлтээ бүртгүүлээгүй эцэг, эхээс төрсөн болон гэрлэгчдийн хэн нэгний нь дагавар хүүхдийг ялгаварлан гадуурхаж, эрх, ашиг сонирхлыг нь хохироохыг хориглосон бөгөөд хэрэв эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн болон хүүхдийн ашиг сонирхол хоорондоо зөрчилдөж байгаа нь тогтоогдсон бол сум, дүүргийн Засаг дарга хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах төлөөлөгчийг томилон зохицуулахаар хуульчилсан байна. Хуулийн энэ заалт амьдрал дээр нэг мөр хэрэгжихгүй байгаагаас гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд хохирсоор байна.

**81.** Монгол Улсын Засгийн газар “Цагаач ажилчид ба тэдгээрийн гэр бүлийг хамгаалах тухай” конвенцид нэгдэн орохоор судалж байна. Ингэснээр Монгол Улсаас бусад улс оронд хөдөлмөр эрхэлж байгаа иргэд, тэдний хүүхдийн эрх ашгийг хамгаалах боломж бүрдэнэ.

### **В. Хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх**

**82.** Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд хүүхэд чөлөөтэй бодож сэтгэх, мэдээлэл хайх, хүлээн авах болон сайн дураараа эвлэлдэн нэгдэх, тайван замаар хуран цуглах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг баталгаажуулсан байна.

**83.** Тайлант 2004–2006 оны хугацаанд гэр бүл, сургуулийн орчинд хүүхдийн

үзэл бодлыг хүндэтгэх, хүүхэд өөрийн эрх ашигтай холбоотой асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх байдлыг хүлээн авах олон нийтийн хандлага өөрчлөгдөж байна. Түүнчлэн хүүхдийг амьдралын бүхий л орчинд зодож шийтгэхийн эсрэг олон нийтийн үйл ажиллагаа эрчимжлээ.

Хүч хэрэглэхгүйгээр хүүхдийг хүмүүжүүлэх арга барилыг сурталчлах, түүнийг сургах, эзэмшүүлэх боловсрол олгох, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах эхлэл тавигдаж байна.

**84.** Боловсролын тухай хуульд суралцагчийн бие даасан байр суурь, үзэл бодолд хүндэтгэлтэй хандаж, түүнчлэн сургууль, цэцэрлэгийн зөвлөлд эцэг, эх, сурагч, сургуулийн захиргааны төлөөллийг оруулж байхаар хуульчилсан байна.

**85.** Монгол Улс бүс нутагтаа хүүхэд, өсвөр үеийнхний оролцоог хөгжүүлэх талаар зохих туршлагатай орны тоонд ордог төдийгүй энэ байр сууриа улам бататгах үүднээс хүүхдийн оролцоог дэмжих төрийн бодлого, арга зүйн үндсийг боловсруулаад байна.

Эрсдэлд байгаа хүүхдийн “Надад хэлэх үг байна” хэлэлцүүлгээр тодорхойлсон арван асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг Хүүхдийн төлөө үндэсний газар бусад холбогдох талуудтай хамтран хэрэгжүүлж байна. *Тухайлбал*, иргэний бичиг баримттай болох; цагдаа нарын харьцааг өөрчлөх; багш нарын авлигыг устгах; хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах; охидыг биеэ үнэлэхээс хамгаалах; халамжийн төвийн хүүхдийг гадуурхдаг байдлыг зогсоох; томчууд хүүхдийн үгийг сонсох; хүүхэд хүнд хөдөлмөр эрхлэхийг хориглох; хүүхдийн боловсролд тууштай анхаарах зэрэг асуудал орсон байна.

**86.** Сургуулийн насны болон өсвөр насны хүүхдүүд цугларах, чуулах боломж бүхий чөлөөт цаг, хөгжлийн байр, газрыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

### **Г. Хүүхдийн амьд явах, амьдрах, эсэн мэнд хөгжих эрх (6 дугаар зүйл)**

**87.** Монгол Улсын Засгийн газар хүүхдийн эрхийн асуудлаар Монгол Улсад өгсөн дүгнэлт, зөвлөмжийн 44 дүгээр заалтын хүрээнд хүүхдийн эрүүл мэнд өсөн бойжих, аюулгүй орчинд амьдрах, хүчирхийллээс ангид байх эрхийг хангах арга хэрэгслийг боловсронгуй болгоход чиглэсэн олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

**88.** Эрүүл мэндийн тухай, Эмийн тухай, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд зарим нэмэлт, өөрчлөлт оруулах замаар салбарын гол харилцааг зохицуулах эрх зүйн шинэчлэлийг эхлээд байна. Тухайлбал, Эрүүл мэндийн тухай хуульд 2006 оны 1 дүгээр сард “Монгол Улсад эх, хүүхдийн эрүүл мэнд төрийн байнгын анхааралд байна”, “Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас эх, хүүхдэд үзүүлэх эмнэлгийн мэргэжлийн тусламж, үйлчилгээний төлбөрийг төр хариуцна” гэсэн нэмэлт заалтыг оруулснаар 18 хүртэл насны хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг төр даах боллоо.

**89.** Бага насны хүүхдийн өвчлөлд амьсгалын замын өвчин, эрт нярайн эмгэг, суулгалт, гэнэтийн осол, халдварт өвчин зэрэг өвчин зонхилж байна. Хүүхдийн эрүүл мэндэд орчны бохирдол ихээхэн нөлөөлж байна. Өвлийн улиралд Улаанбаатар болон томоохон хот, суурин газарт цахилгаан станц, уурын зуух, айл өрхийн нүүрсний утаа, автомашины утаа агаарыг бохирдуулж амьсгалын замын өвчин үүсгэх, улмаар дулаан

улиралд ил задгай асгасан хог, ус хөрсний бохирдол халдварт өвчин үүсгэх гол хүчин зүйл болж байна. Түүнчлэн ундны усан хангамж бол хүүхдийн эрүүл мэнд, амьд явах, өсөж хөгжихөд чухал хүчин зүйлийн нэг билээ. Монгол Улсын хүн амын 44.6 хувь нь сайжруулсан ундны усны эх үүсвэрээс усаа хэрэглэж байгааг Дэлхийн банкны 2005 оны судалгаанд тэмдэглэсэн байна. Хотын болон төв, суурин газрын гэр хороололд амьдарч байгаа өрхийн нэг хүний өдрийн дундаж хэрэглээний усны хэмжээ 8–10 литр байгаа нь эрүүл ахуйн наад захын шаардлага, нормоос 5 дахин бага байна.

**90.** Хүнсний нийт бүтээгдэхүүнийхээ 70 гаруй хувийг импортоор авдаг манай орны хувьд хүнсний аюулгүй байдал тулгамдсан асуудлын нэг болоод байна.

**91.** Гар аргаар алт олборлох үйл ажиллагаанд мөнгөн ус, цианит натрийг ашиглах явдал нэмэгдсэнээс зарим нутагт газрын хөрс, амьдралын орчин зохих хэмжээгээр бохирдсоноос тэнд ойр амьдардаг хүн, гэрийн тэжээвэр мал, амьтан хордох боллоо.

**92.** Монгол Улсад 2003–2005 онд 42567 хүүхэд авто хэрэгслийн болон ахуйн ослоор гэмтсэн байна. Энэ үзүүлэлт сүүлийн жилүүдэд байнга өсөх хандлагатай байна. Хүүхэд, ялангуяа амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн хүүхэд ихэвчлэн гэр бүл, сургуулийн орчинд осолд өртсөн байна. Үүнд эцэг эх, асран хамгаалагчдын анхаарал халамж дутсан, хүүхдийн тоглох, зорчих аюулгүй орчныг хангаагүй байдал нөлөөлж байна.

#### **Д. Хамгийн эмзэг бүлэгт хамаардаг хүүхдийн эрхийн хэрэгжилтийн байдал**

**93.** Монгол Улсад хамгийн эмзэг бүлэгт хамаардаг хүүхдийг хүнд болон онцгой хүнд нөхцөлд байгаа хүүхэд гэж ангилан үздэг бөгөөд эдгээр хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг тайлангийн наймдугаар бүлэгт оруулсан болно.

**94.** Монгол Улсын Эрүүгийн хуулиар 18 нас хүрээгүй хүнд цаазаар авах ял оноохыг хориглосон болно.

#### **Е. Хүүхдийн нас баралтын бүртгэл хөтлөх, шаардлагатай нөхцөлд**

##### **мөрдөн шалгах, мэдээлэх**

**95.** Иргэний бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд хүүхдийн (иргэний) нас барсныг түүний эцэг, эх, төрөл садан, бусад хүн, улмаар ажиллаж, суралцаж, эмчлүүлж, сувилуулж, цэргийн алба хааж байсан байгууллагын захиргаа төв суурин газарт 5 хоногт, орон нутагт 10 хоногт, түүнчлэн тодорхой биш шалтгаанаар нас барсан буюу цогцос олдсон тохиолдолд цагдаагийн байгууллага төв суурин газар болон орон нутагт 10 хоногт нас барагчийн оршин сууж байсан, эсхүл нас барсан, цогцос олдсон газрын сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт бүртгүүлнэ. Иргэний нас барсныг сум, дүүргийн Засаг даргын тамгын газар нас барсан тухай эмнэлгийн магадлагаа; нас барагчийг оршуулсан тухай тодорхойлолт; тухайн иргэнийг нас барсан тухай зарласан шүүхийн шийдвэр буюу түүний хуулбар; нас барсан шалтгааны талаар гарсан шүүх эмнэлгийн дүгнэлт зэрэг баримт бичгийн аль нэгийг үндэслэн бүртгэнэ.

**96.** Цагдаагийн болон шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагад гэмт хэрэг үйлдсэний улмаас цагдан хорихоор таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан буюу хорих газар ял эдэлж байгаа хүн нас барсан бол нас барагчийн оршин сууж байсан газрын сум,

дүүргийн Засаг даргын тамгын газарт, хэрэв оршин сууж байсан газар нь тодорхойгүй бол тухайн цагдаагийн буюу хорих байгууллагын оршин байгаа газрын сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт тус тус бүртгүүлж, нас барсны гэрчилгээг нас барагчийн төрөл саданд нь хүргүүлж байхаар хуульчилсан байна.

**97.** Өнгөрсөн 2004 онд 0–19 насны 1762 хүн нас барсны 1016 нь 0–1 настай хүүхэд байсан бол 2006 онд 1610 хүн барсны 937 нь 0–1 настай хүүхэд байв. Харин 2004 онд 0–19 насны нийт нас барагчдын 40.1 хувь, 2006 онд 43.7 хувь нь эмэгтэй хүүхэд байна (ҮСГ статистикийн эмхтгэл 2006). Хүүхэд гол усанд живэх, төөрөх, алга болох, осгож хөлдөх, түүнчлэн төв, суурин газарт ухсан нүх, суваг шуудуу, таглаагүй худагт унаж амь насаа алдах явдал гарч байна. Сүүлийн хоёр жилд Хөвсгөл аймагт хүйтэн бороонд осгож хоёр, ор сураггүй алга болсон нэг, нийслэлийн Налайх дүүрэгт цасан шуурганд төөрч нэг, эвдэрхий хөргөгчид нуугдаж тоглоод бүтэж хоёр, хөлсөөр ажиллаж байсан айлын эзнийхээ байнгын дарамт, хүчирхийлэлд өртөж, зодуулсны улмаас нэг хүүхэд амь насаа алдсан гэсэн бүрэн бус мэдээ байна.

#### **Ё. Хүүхдийн дунд амиа хорлох явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ**

**98.** Судалгаанд оролцсон өсвөр үеийнхэн хариулахдаа: тэдэнд тулгарч буй гол асуудал бол амьдралын янз бүрийн бэрхшээлээс болоод амьдралдаа гутрах, түүнээс болж амиа хорлох явдал гардаг гэжээ. Хордлогын яаралтай тусламжийн төвд 2000 онд 16–25 насны 170 (56 хувь) залуус, өсвөр үеийнхэн цочмог хордлогын улмаас эмчлүүлжээ. Амиа хорлохоор оролдсон хүмүүс эм, түүн дотроо тайвшруулах эмэнд хордсон байна. Эх, нялхсын эрдэм шинжилгээний төвд 13–16 насны 40 хүүхэд амиа хорлох оролдлого хийсний улмаас ирж эмчлүүлжээ. Судалгаанд хамрагдсан 20 хүүхэд тутмын нэг нь янз бүрийн сэтгэлийн дарамтаас болж амиа хорлохоор оролдсон бөгөөд охид (60 хувь) илүүтэй өртсөн байна. Ийм оролдлогыг ажил, сургуульгүй залуучууд, хүүхдүүд илүүтэй хийжээ. Эмгэг судлал, шүүх эмнэлгийн төвийн мэдээгээр сүүлийн 5 жилд 745 хүн амиа хорлож нас барсны 5 хувь нь өсвөр үеийнхэн байв<sup>2</sup>. Хүүхдийн аюулгүй байдал, ялангуяа бага насны хүүхдэд тавих анхаарал халамж суларснаас шалтгаалан хүүхэд амь насаа алдах золгүй тохиолдол гарч байна.

**99.** Өсвөр үеийнхний бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаар тайлангийн зургадугаар бүлэгт дурдсан болно.

**100.** Төрийн болон төрийн бус байгууллагуудын “Нийгмийн дэг журам” сүлжээ нь 2003 онд байгуулагдсан бөгөөд сүлжээнийхэн гудамжны дээрэм, хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ухуулга, сурталчилгааны ажлыг хамтран зохион байгуулж байна.

<sup>2</sup> Өсвөр үеийн эрүүл мэнд, хөгжил судалгаа, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, 2003, хуудас 16



**Дөрөвдүгээр бүлэг. Иргэний эрх, эрх чөлөө**

(7, 8, 13, 17 ба 37-гийн "а" заалт)

**101.** Хүүхдийн эрх, эрх чөлөөг үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулсан мэдээллийг Монгол Улсын үндэсний хоёрдугаар илтгэлийн хоёрдугаар бүлэгт буюу 6–7 дахь тал, гуравдугаар бүлэгт буюу 11–15 дахь талд оруулсан болно.

**А. Нэр болон угсаа, хувь хүний халдашгүй дархан байдал**

**102.** Үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулсан мэдээллийг Монгол Улсын үндэсний хоёрдугаар илтгэлийн хоёрдугаар бүлэгт буюу 6–7 дахь талд танилцуулсан болно.

**103.** Хүүхдийн халдашгүй дархан байдалд халдах явдал хэвлэл, мэдээллийн байгууллагын хувьд гарсаар байна. Энэ асуудал сэтгүүлчийн ёс зүй, хариуцлагын тогтолцоо хангалтгүй байгаагаас голлон шалтгаалж байна.

**Б. Үг хэлэх эрх чөлөө**

**104.** Үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулсан мэдээллийг Монгол Улсын үндэсний хоёрдугаар илтгэлийн хоёрдугаар бүлэгт буюу 7 дахь талд танилцуулсан болно.

**105.** Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд хүүхдийн төлөөлөл оруулах, хүүхдийн оролцоо бүхий хэлэлцүүлэг, зөвлөлгөөн зохион байгуулах зэргээр хүүхэд, өсвөр үеийнхний дуу хоолойг бодитой дэмжиж байна. Түүнчлэн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүүхэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж нээлттэй болсоор байна. *Тухайлбал*, харааны бэрхшээлтэй хүүхдийн 116 дугаар тусгай сургуулийн сурагчдын сургуулийн удирдлагаас сурах эрхээ хүндэтгэхийг шаардсан үйл явцыг дурдаж болно.

**106.** Хүүхдийн санал бодлыг хүлээн авах, шийдвэрлэх, түүний дагуу арга хэмжээ авах, үр дүнг хүүхдэд тайлагнах тогтолцоог хөгжүүлэх шаардлагатай байна.

**В. Чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, сүсэглэх эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх, тайван замаар хуран цуглах эрх чөлөө**

**107.** Үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулсан мэдээллийг Монгол Улсын үндэсний хоёрдугаар илтгэлийн хоёрдугаар бүлэгт буюу 6–7 дахь тал болон гуравдугаар бүлэгт буюу 13–15 дахь талд оруулсан болно.

**108.** Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийг хүүхэд чөлөөтэй бодож сэтгэх чадвар, бүтээлч сэтгэлгээгээ хөгжүүлэхэд чиглүүлэн өөрчилж байна. Сурах бичигт энэ зарчмыг мөрдөж ажиллахыг зохиогчоос шаарддаг боллоо.

**109.** Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг Үндсэн хуулиар баталгаажуулсан билээ. Тус улсын уламжлалт шашин бол бөөгийн болон бурханы шашин мөн боловч сүүлийн жилүүдэд өөр шашны урсгал орж ирсээр байна. Эдгээр шашныхан эмзэг бүлгийн гэр бүл, хүүхдэд нийгмийн халамж, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж байна. Ялангуяа шашны байгууллагын санхүүжилт бүхий халамжийн байгууллагууд шашны төрөл бүрийн ёс жаягт бага насны хүүхдийг албадан сургах үйл ажиллагаа явуулж байгааг хяналт шалгалтын баг илрүүлж, зөвлөгөө чиглэл өгч байна.

**Г. Хувийн нууц хамгаалах**

**110.** Хувийн нууц хамгаалах асуудлыг үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулсан мэдээллийг Монгол Улсын үндэсний хоёрдугаар илтгэлийн хоёрдугаар бүлэгт буюу 6–7 дахь талд танилцуулсан болно.

**111.** Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлд “Хүүхэд нэр төр, эрүүл мэнд, хувийн болон захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлаа хамгаалуулах эрхтэй” гэсэн нэмэлт, өөрчлөлтийг 2003 онд оруулсан юм.

**112.** Түүнчлэн Хувийн нууцын тухай, Боловсролын тухай, Нийгмийн халамжийн тухай болон Эрүүл мэндийн тухай хуульд хувийн нууцыг хамгаалах заалтыг оруулсан байна.

**113.** Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дүнгийн нууцлалыг хамгаалах арга хэрэгслийг 2005 оноос эхлэн нэвтрүүлж, сурагчид зөвхөн өөрсдөө л дүнгээ мэдэж байх боломжтой болгосон юм. Энэ арга хэрэгслийг их, дээд сургуулийн элсэлтийн үйл ажиллагаанд мөн нэвтрүүлж байна.

**Д. Зохистой мэдээллийг олж авах, хүртэх**

**114.** Олон нийтийн радио, телевизийн тухай, Тамхины хяналтын тухай, Садар самуунтай тэмцэх тухай, Зар сурталчилгааны тухай зэрэг хуульд хүүхдэд шаардлагатай мэдээллийг хүргэх, түгээх асуудлыг зохицуулсан байна.

**115.** Мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хуулийн төслийг боловсруулан холбогдох талууд, олон нийтээр хэлэлцүүлж байна. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолоор иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх журмыг шинэчлэн мөрдөж байна. Эдгээр хууль тогтоомж нь төрийн захиргааны байгууллага иргэдэд хүнд сурталгүй, түргэн шуурхай үйлчлэх үйл ажиллагааг зохицуулсан байна. Гэхдээ хүүхдэд хандсан тодорхой заалт, зохицуулалт байхгүй байна.

**116.** Хүүхэд, өсвөр үеийнхний мэдээлэл хүртэх боломжийг нэмэгдүүлэхэд мэдээлэл харилцааны технологийн төрөл бүрийн сүлжээг үндэсний хэмжээнд байгуулж, нэгж бүрийг мэдээлийн нэгдсэн сүлжээнд холбох замаар түүний ашиглалтын агуулга, хэлбэрийг өргөжүүлэх явдал чухал ач хогбогдолтой юм.

“Бүх нийтийг компьютержуулах” үндэсний хөтөлбөрийн хүрээнд иргэдийн компьютер худалдан авах боломжийг нэмэгдүүлэх, компьютерийн үнэ тарифыг хямдруулах, улмаар зээл, түрээсийн үйлчилгээний хэлбэрийг өргөжүүлэхийг зорьж ажиллаж байна. Улсын хэмжээнд 2006 оны байдлаар 99.6 мянган өрх гэртээ компьютер ашигладаг болжээ. Түүнчлэн Монгол Улсад үүрэн телефоны дөрвөн оператор үйл ажиллагаа эрхэлж нэг сая гаруй хэрэглэгчид үйлчилгээ үзүүлж байна. Өндөр хурдны шилэн кабель аймаг, орон нутагт тавих ажил эрчимтэй явагдаж байна.

**117.** Хөдөөгийн иргэдийг эрчим хүчээр хангах хөтөлбөрийн хүрээнд алслагдсан сум, суурин газрыг төвийн эрчим хүчинд холбох, 50 шахам мянган малчин өрхийг сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр хангах ажил сүүлийн жилүүдэд эрчимтэй хийгдсэн явдал олон мянган хүүхдэд телевизээр дамжуулан мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлээ.

Сүүлийн гурван жилд 40 гаруй сум, суурин газрыг төвийн эрчим хүчинд холбож, олон мянган малчин өрх сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр хангагдсан байна. Түүнчлэн

эрчим хүчний бусад эх үүсвэрийг өргөн ашиглах боллоо.

**118.** “Орон нутгийн мэдээлэлжүүлэлт” төслийн хүрээнд 2006 онд Монгол Улсын бүх аймаг, сум болон Улаанбаатарын алслагдсан дүүрэг, суурин газар буюу нийт 353 цэгт телевизийн дөрвөн сувгийг сансраас хүлээн авах, дамжуулах тоног төхөөрөмжийг суурилууллаа. Түүнчлэн Увс, Баян-Өлгий, Ховд аймгийн радио өргөн нэвтрүүлгийн станцыг шинэчлэн нэвтрүүлгийн чанарыг сайжруулж байна.

**119.** Өнөөдөр хүүхдэд зориулсан сонин, сэтгүүл, ном зэргийг хэвлэх талаар хувийн хэвшлийн байгууллага, хувь хүмүүсийн оролцоо, үйл ажиллагаа өргөжих хандлага ажиглагдаж байна. (Мэдээг статистик хавсралтаас үзнэ үү). Монголын үндэсний радио, телевизийг хоёр жилийн өмнө Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз болгон хуульчилсан байна.

**120.** Өнгөрсөн 2006 оныг 2002 онтой мэдээллийг харьцуулахад хүүхдэд зориулсан радиогийн нэвтрүүлгийн цаг, давтамж хоёр дахин, хүүхдэд зориулсан телевизийн нэвтрүүлгийн эфирт эзлэх цаг 1.2 дахин өссөн байна. Манай улсад 2007 оны байдлаар олон нийтийн 1, хувийн хэвшлийн 11 телевиз ажиллаж бүгд хүүхдэд зориулсан танин мэдэхүй, чөлөөт цагийн нэвтрүүлэг бэлтгэн үзүүлж байгаа нь нийтдээ долоо хоногт 77 цаг болж байна.

**121.** Үндэсний цөөнхөд зориулсан телевизийн болон радио нэвтрүүлгийг олон нийтийн телевиз, радиогоор явуулах бодлогыг Засгийн газар дэмжин ажиллаж байна. Үндэсний цөөнх болсон казак иргэд амьдардаг Баян-Өлгий аймгийн радио, телевизийн техник төхөөрөмжийг шинэчиллээ.

**122.** Богино долгионы радио болон телевизийн зарим нэвтрүүлэг хүүхдийн хөгжил, танин мэдэхүйн эрэлт хэрэгцээг тэр бүр хангаж чадахгүй байгаагаас гадна хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохироогүй нэвтрүүлэг, зар сурталчилгааг хүүхдийн үзэх, сонсох цагаар олон давтамжтайгаар явуулж байна. Засгийн газраас мэдээллийн хүртээмж, чанарыг сайжруулах, төрийн захиргааны байгууллага, ажилтан нарын ажлын ил тод байдлыг хангах, төрийн үйлчилгээний шуурхай байдлыг нэмэгдүүлэх арга хэмжээний талаар төрөл бүрийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа ч хүүхэд өөрийнхөө эрх ашгийг хөндсөн, өөрт үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийг олж авах, хүртэх эрх нь хязгаарлагдсан хэвээр байгааг энэ чиглэлээр явуулсан хэд хэдэн судалгааны үр дүн харуулж байна.

**Е. Эрүү шүүлт, хэрцгий, хүнлэг бус харьцаа, доромжлол, бие махбодын шийтгэлээс хамгаалагдах эрх**

**123.** Үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулсан мэдээллийг Монгол Улсын үндэсний хоёрдугаар илтгэлийн хоёрдугаар бүлэгт буюу 6–7 дахь тал болон гуравдугаар бүлэгт буюу 13–15 дахь талд оруулсан болно.

**124.** Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд хүүхдэд хэрцгий, хүнлэг бус харьцах, доромжлох, бие махбодын шийтгэл үзүүлэхийг хориглосон бол Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хэрэг мөрдөн байцаалтын үйл ажиллагаанд эрүү шүүлтийг ашиглахыг хориглосон байна. *Тухайлбал*, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь заалтад “Хүүхэд...хүчирхийллээс ангид байх эрхтэй”, мөн хуулийн 7 дугаар зүйлийн 4 дэх заалтад “Хүүхдийг ... доромжлох, басамжлах, гүтгэх, хүчирхийлэх,

хулгайлах, барьцаанд авах, худалдах; дамжуулан худалдах, боолчлох буюу түүнтэй адилтгах нөхцөлд байлгах, санаатай солих, хаях, төөрүүлэх; ...тарчлаан зовоох”-ыг хориглосон байна.

Энэ хуулийн эдгээр заалтыг зөрчсөн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай иргэн, албан тушаалтныг сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр 40000–50000 төгрөгөөр торгох буюу 30 хүртэл хоногоор баривчлахаар заасан байдаг.

**125.** Гэр бүлийн орчинд бие махбодын шийтгэлээс хүүхдийг хамгаалах зорилгоор олон нийтийн дундах ойлголтыг дээшлүүлэх үйл ажиллагааг Английн Хүүхдийг ивээх сан, Дэлхийн зөн Монгол зэрэг байгууллагуудын санхүүгийн болон техникийн дэмжлэгтэйгээр явуулж байна. Энэ хүрээнд Хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргууд номыг хэвлэн гаргасан бөгөөд эцэг, эхэд хүүхэдтэй ажиллах талаарх зөвлөгөө, үйлчилгээг 24 цагийн турш төрийн бус байгууллагууд үзүүлэх боллоо.

Хүүхдийн төлөө үндэсний газарт хүүхдийн утас 19–79; Хүүхдийг хүчирхийллээс хамгаалах төвийн дотно яриа–464060; Өсвөр үе–ирээдүй төвийн нөхөн үржихүйн талаар зөвлөгөө өгөх–312151; Хүйсийн тэгш эрхийн төвийн итгэлийн утас–1903; Хүн худалдах гэмт хэргээс сэргийлэх талаар зөвлөгөө өгөх–99927644; Өсвөр үе– ирээдүй төвийн 1930; Тэгш мөр төвийн 70150150; Нийслэлийн цагдаагийн газрын 130 зэрэг дугаарын утсыг өдөр, шөнийн цагаар тасралтгүй ажиллуулж байна. Эдгээр утсаар дамжуулан хүүхдийн эрхийн асуудлаар мэргэжлийн байгууллагуудад хандаж дэмжлэг авах боломжтой боллоо.

**126.** Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тайлан болон НҮБ–ын эрүү шүүлтийн асуудлаарх тусгай илтгэгч Манфред Новакийн илтгэлд эрүүдэн шүүх ба бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэх явдал шүүх засаглалын үйл ажиллагаанд гарсаар байгааг тэмдэглэн тодорхой зөвлөмж гаргасан байна.

**Ё. Нийгмийн эмзэг бүлэгт хамаардаг буюу хүнд нөхцөлд байгаа хүүхэд, түүнчлэн орогнол хайгч, дүрвэгч болон үндэстний цөөнх, уугуул нутгийн хүүхдийн эрхийн хэрэгжилтийн байдал**

**127.** Орогнол хайгч, дүрвэгч болон үндэстний цөөнхийн эрүү шүүлт, хэрцгий, хүнлэг бус харьцаа, доромжлол, бие махбодын шийтгэлээс хамгаалагдах эрхийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл, судалгаа одоогоор алга байна. Монгол Улсын хувьд тэдэнд Монгол Улсын хууль тогтоомж ижил нөхцөлөөр үйлчилж байдаг.

**128.** Нийгмийн эмзэгт бүлгийн хүүхдийн үг хэлэх эрх, эрх чөлөөг хангах чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтран тогтмол үйл ажиллагааг явуулж байна. “Инээж буй хүүхэд” чуулган, “Хүүхэд насаа хайрлая” үндэсний зөвлөлгөөн болон аймаг, нийслэлийн хүүхдийн чуулган зэргийг уламжлалт үйл ажиллагаа болгон зохиож байна.

**Тавдугаар бүлэг. Гэр бүлийн орчин ба асран хамгаалалт**  
(5, 9–11, 18 дугаар зүйлийн 1 ба 2 дахь заалт, 19–21, 25, 27 дугаар зүйл,  
4 дүгээр бүлэг болон 39 дүгээр зүйл)

**129.** Үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулсан мэдээллийг Монгол Улсын үндэсний хоёрдугаар илтгэлийн дөрөвдүгээр бүлэгт буюу 16–19 дахь талд танилцуулсан билээ. Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн дүгнэлт, зөвлөмжийн 32 дугаар заалтын дагуу гэр бүл, эцэг эхэд шаардлагатай санхүүгийн болон бусад тусламж үзүүлэх, эцэг эхийн хариуцлагыг нэмэгдүүлэх талаар олон талт арга хэмжээг хэрэгжүүлж байна.

**130.** “Төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Тогтвортой амьжиргаа”, “Хүүхдийн мөнгө”, “Дөчин мянган орон сууц” зэрэг гэр бүлийн хөгжилд чиглэсэн томоохон хөтөлбөрийг дэмжин ажиллаж байна. Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийг дэмжих талаар баримтлах бодлого нь гэр бүлийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийг дэмжих, гэр бүлийн хөгжил, үр хүүхдээ асран хамгаалахад эцэг эхийн жигд оролцоог хангах, гэр бүлийн өмчийн харилцаанд гэр бүлийн гишүүдийн тэгш оролцоог хангах, хүн амын эмзэг бүлгийн нийгмийн халамж, хамгааллын арга хэмжээг гэр бүлд төвлөрүүлэх, гэр бүлд түшиглэсэн үйлчилгээний сүлжээ бий болгох, гэр бүлийн гишүүдийг хүчирхийллээс хамгаалах, гэр бүлийн харилцааны эерэг орчныг бүрдүүлэх, гэр бүлийн асуудлаар мэргэшсэн боловсон хүчинг бэлтгэхэд чиглэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “Хүүхдийн мөнгө” хөтөлбөр нь нийгмийн халамжийн бодлогыг гэр бүлд төвлөрүүлэхэд чиглэсэн нэг чухал арга хэмжээ боллоо. “Дөчин мянган орон сууц” хөтөлбөрийг бодитой хэрэгжүүлснээр залуу болон бага, дунд орлоготой гэр бүлийг хямд өртөгтэй орон сууцаар хангах, тэднийг орон сууцны урт хугацааны зээлд хамруулах хууль эрх зүйн болон эдийн засгийн боломж нээгдэж эхэллээ.

**131.** “Дөчин мянган орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулан Засгийн газраас 2007 онд 60.0 тэрбум төгрөгийн бонд гарган борлуулж, бага, дунд орлоготой өрхөд зориулан 5500 орон сууц барих урт хугацааны зээлийн эх үүсвэр болгон ашиглахаар ажиллаж байна.

**132.** Монгол Улс хүүхэд өөрийнхөө бие бялдар, оюун ухаан, ёс суртахуун, нийгмийн хөгжлийн түвшинг хангахуйц орчинд амьдрах эрхтэйг хүлээн зөвшөөрч шаардлагатай хот байгуулалт, барилга, орон сууц, зам тээврийн зэрэг салбарын норм стандартыг шинэчлэн хот, суурин газруудад хүүхдийн тоглоомын талбай, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, шатны стандартуудыг гаргаад байна. Эдгээр стандартын хэрэгжилтийг сайжруулах, хяналт шалгалтыг эрчимжүүлэх явдал чухал байна.

**А. Эцэг, эхийн асрамж, үүрэг, хариуцлага**

**133.** Гэр бүлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд “Хүүхдийг гэр бүлийн дотор эрүүл чийрэг өсгөн хүмүүжүүлэх, хөгжүүлэх, түүний эрх, ашиг сонирхлыг нэн тэргүүнд хамгаалахыг эрхэмлэнэ” гэж заасан болно. Мөн хуулийн 10 дугаар зүйлд “Гэрлэгчид нь бие биедээ үнэнч байх, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, гэр бүлийн гишүүд нь бие биеэ халамжлах, хүндэтгэх, тэжээн тэтгэх, туслах, гэр бүлд шаардагдах эдийн засгийн

нөхцөлийг бүрдүүлэх, хэн нэгнийхээ эрхийг зөрчихгүй, бие биеэ аливаа хэлбэрээр хүчирхийлэхгүй байх, угийн бичиг хөтлөх үүргийг адил хүлээх” –ээр хуульчилсан байна.

Гэр бүлийн тухай хуулийн 25 дугаар зүйлд “Хүүхэд гэр бүлийн дотор тэгш эрх эдэлнэ”, 26 дугаар зүйлд “Эцэг, эх хүүхдээ хүмүүжүүлэхэд тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээнэ” гэж заасан бөгөөд хүүхдээ эрүүл чийрэг өсгөн бойжуулах, сэтгэхүйн хувьд төлөвшүүлэх, хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх, хүүхдээ үндэсний ёс заншил, уламжлалаа дээдлэх үзлээр хүмүүжүүлэх, түүнд суурь боловсрол эзэмшүүлэх, хөдөлмөрийн анхны дадлага олгох, хүүхдийн эрхийг хамгаалж, үүргээ биелүүлэхэд нь туслах үүргийг хүлээлгэсэн байна.

**134.** Гэр бүлийн гишүүдийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, гэр бүлд хүчирхийлэлгүй амар амгалан байдлыг бүрдүүлэх, эрэгтэйчүүдийн бодитой оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн таниулан ойлгуулах, сурталчлах үйл ажиллагааг төрийн бус байгууллагуудтай хамтран явуулж байна.

**135.** Эрэгтэй хүний болон өрхийн тэргүүний үүргийг нэмэгдүүлэх сурталчилгаанд улсын төсвөөс хоёр сая төгрөгийг зарцуулсан байна. Түүнчлэн 2006 онд шинээр гэр бүл болсон 22.1 мянган өрхөд 11 тэрбум төгрөгийн мөнгөн тусламж, шинээр мэндэлсэн 41.1 мянган хүүхдэд 4 тэрбум төгрөгийн мөнгөн тусламжийг тус тус нийгмийн халамжийн сангаас үзүүлсэн байна.

**136.** Нийгмийн халамжийн тухай хуульд дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэг нийгмийн халамжийн тэтгэвэр авах эрхтэй байхаар тусгаж өгсөн байна. Засгийн газраас гэр бүлийн талаар тодорхой арга хэмжээг авсан хэдий ч эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо 2004 онд 65 мянга байсан бол 2006 онд 7000 орчмоор нэмэгдсэн байна.

Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо өсөхөд нийгмийн ядуурал, боловсролын ялгаа, гадаадад ажиллах иргэдийн шилжилт хөдөлгөөн нэмэгдсэн зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна. Гэр бүлээ 2004 онд 1098 хүн цуцлуулсан бол 2006 онд 1448 хүн цуцлуулсан байна. Тэдний 60 орчим хувь нь 10–аас дээш жил ханилан аж төрсөн хүмүүс байна. Энэ нь гэр бүл салалтын үйл явц хүүхдийн эрх ашигтай ихээхэн уялдаатай болохыг нотолж байна.

**137.** Гэр бүлийн харилцааны зохицуулалт, хэрэгжүүлэлт, хяналт, санхүүжилтийн үйл ажиллагаа төвлөрсөн бус тогтолцоотой байна. Аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга, тамгын газрын нийгмийн бодлогын хэлтэс, харьяа агентлагууд тухайн орон нутгийн түвшинд төрөөс гэр бүлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, тайлагнах үүргийг хүлээж байна.

Сум, хорооны Засаг дарга, нийгмийн ажилтан нар Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай болон Хүүхдийн эрхийг хамгаалах тухай, Нийгмийн халамжийн тухай зэрэг хуулийн хүрээнд олгогдсон эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллаж байна.

**138.** Гэр бүлийн тухай хуулийн 25 дугаар зүйлд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн болон хүүхдийн ашиг сонирхол хоорондоо зөрчилдөж байгаа нь тогтоогдсон бол сум, дүүргийн Засаг дарга хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах төлөөлөгчийг томилж болохоор заажээ.

Бүтэн өнчин, эцэг, эх нь хоёулаа эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан, удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа,

хорих газарт ял эдэлж байгаа зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй, эсхүл тэжээн тэтгэхээс зайлсхийсэн хүний хүүхдийн эрх, ашиг сонирхлыг сум, дүүргийн Засаг дарга хамгаалж, хүүхдийн эрх ашиг зөрчигдсөн тухай мэдээллийг ясли, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлгийн байгууллагын холбогдох албан тушаалтан болон иргэн хүүхдийн оршин суугаа (оршин байгаа) газрын сум, дүүргийн Засаг даргад өгөх үүрэгтэй юм.

Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын 1996 оны 91 дүгээр тогтоолд нийцүүлэн Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар баталсан журамд заасны дагуу цагдаагийн байгууллагаас шилжүүлсэн хүүхдийг хүлээн авсан хүүхдийн буюу харгалзан дэмжих байгууллага нь гурав хоногийн дотор энэ тухай сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэх үүрэгтэй бөгөөд сум, дүүргийн Засаг дарга хүүхдийн тухай мэдээллийг хүлээн авснаас хойш гурав хоногийн дотор хүүхдийн амьдралын нөхцөлийг судалж, эцэг, эх болон төрөл садангийн хүн байхгүй нь тогтоогдсон бол түүний эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүрэг хүлээж, сум, дүүргийн Засаг дарга хүнд нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж, бүртгэл хөтлөн, түүнийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэхээр хүсэлт гаргасан иргэнд шилжүүлэх, эсхүл шилжүүлэх боломжгүй бол сум, дүүргийн Засаг дарга асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгох, үрчлүүлэх, хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэж байх үүрэг, эрх мэдлийг Засаг даргад хүлээлгэсэн байдаг.

Энэ үүргийг ханган биелүүлэх арга хэрэгсэл тодорхой бус байдгаас хуулийн заалт хэрэгждэггүй, түүний хэрэгжилтийг дүгнэж тооцдоггүй байна. Түүнчлэн хуулийн заалтын хэрэгжилтэд төрийн захиргааны болон олон нийтийн зүгээс тавих хяналт үгүйлэгдэж байна.

**139.** Нийгмийн ажилтан нь орон нутгийн нийгмийн эмзэг бүлгийн болон ядуу өрх, иргэдийн тооны ба хэрэгцээний судалгаа гаргах, нийгмийн халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдах өрх, иргэнийг тодорхойлон шийдвэрлүүлэх, нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг хүсэл зорилго, хэрэгцээгээрээ бүлэгт нэгдэн ажиллахад мэргэжил, аргазүйн туслалцаа үзүүлэх, нийгмийн эмзэг бүлэг, ядуу, нэн ядуу өрх иргэдийг амьжиргаагаа дээшлүүлэх чадавхитай болгоход зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах, орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагыг мэдээллээр хангах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, хамтран ажиллах чиг үүргийг хүлээж байна.

**140.** Гэр бүлийн талаар орон нутгийн түвшинд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, санхүүжилт, хөрөнгө оруулалтын тухай мэдээлэл бага байна. Иргэний бүртгэл мэдээллийн байгууллага гэрлэлт, салалт, цуцлалт, шүүхийн шийдвэрээр тэтгэлэг авдаг хүүхдийн тоо зэрэг статистик мэдээллийг гаргаж байна.

**141.** Хүүхдийн осол гэмтлийн өнөөгийн байдал (2003–2005) гэсэн судалгааг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, НҮБ-ын Хүүхдийн сан болон Хүүхэд өсвөр үеийг ивээх төв хамтран хийсэн байна. Энэ судалгаанаас үзэхэд Гэмтэл согог судлалын үндэсний төв, Эх, нялхсын эрдэм шинжилгээний төвд осол гэмтлийн улмаас хэвтэж эмчлүүлсэн хүүхдийн тоо жил дараалан өссөн байна. *Тухайлбал*, осол гэмтэлд 2003 онд 16199, 2004 онд 16526, 2005 онд 17174 хүүхэд өртсөн байна.

Осол гэмтэлд 2005 онд өртсөн 17174 хүүхдийн 68.3 хувь нь эрэгтэй хүүхэд бөгөөд насны бүлгээр үзвэл 1 хүртэлх насны 678, 1–4 насны 2732, 5–15 насны 9401, 16–8 насны 4363 хүүхэд байна. Харин 2003–2005 оны 18 хүртэлх насны хүүхдийн гэмтлийн шалтгааныг судлан үзвэл явганаас бэртсэн 19.4 хувь, автомашины осол 14.9 хувь, зодуулсан 10.3 хувь, өндрөөс унасан 9.8 хувь, мориноос унасан 1.9 хувь, үлдсэн хувийг ахуйн бусад осол эзэлж байв.

**142.** Хүүхдийн эрх гэр бүлийн орчинд зөрчигдсөн тохиолдолд үйлдлийг таслан зогсоох, хүүхдэд үйлчилгээ үзүүлэх, нөхөн сэргээх ажиллагаа хангалтгүй хэвээр байна. Энэ нь нэг талаас хүүхэд залуусын хүмүүжилд хандах уламжлалт хандлага ноёлж, нөгөө талаас хүүхдэд чиглэсэн үйлчилгээний нэр төрөл хомс байгааг харуулж байна.

**143.** Нийгмийн халамжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “нөхцөлт мөнгөн тэтгэмж, нийгмийн халамжийн тусламж, хөнгөлөлт, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах өрх, иргэнийг тодорхойлох үүрэг бүхий Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөл сум, хороонд ажиллана” гэж заасан байна.

Амьжиргааг дэмжих зөвлөл нөхцөлт мөнгөн тусламж, нэн ядуу иргэнд орон сууцны хөлс төлөх, түлээ, нүүрс худалдан авахад зориулан жилд нэг удаа олгох мөнгөн тусламж, халамжийн цэцэрлэгийн үнийн хөнгөлөлт, протез, ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн хангамж, сэргээн засах үйлчилгээний зардлын хөнгөлөлт, эх орны рашаан сувиллын зардлын хөнгөлөлт, тусламж, түүнчлэн амьдралын итгэл үнэмшил, хөдөлмөрийн дадал олгох, авъяасыг дэмжих зорилгоор зөвлөлгөө өгөх, сургалт зохион байгуулах, зохион байгуулалттайгаар хөдөлмөр эрхлүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох зэргээр ядуурлаас гарахад туслах, энэ чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт зуучлах, сэргээн засах үйлчилгээнд хамруулах, түр байрлуулан асрамжлах, гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах зэрэг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг үзүүлж байна.

Хүүхдийн хамгааллын үйлчилгээний талаар 6 дугаар бүлэгт дэлгэрэнгүй танилцуулсан болно.

**144.** Гэр бүлийн орчинд хүүхдийн бие махбодын шийтгэлийг бүрэн хориглох, хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга барилыг дэмжих зорилгоор Засгийн газар Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг санаачлан боловсруулж, түүнийг гэр бүл, олон нийт, иргэний нийгмийн байгууллагын оролцоотойгоор хэлэлцүүлэг зохион байгуулж байна.

## **Б. Эцэг, эхээс нь салгах**

**145.** Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх заалтад 18 хүртэл насны хүүхэдтэй гэрлэгчдийн харилцан тохиролцсон буюу тэдний хэн нэгний, эсхүл иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй гэж тооцогдсон эхнэр, нөхрийн асран хамгаалагчийн нэхэмжлэлийн дагуу гэрлэлт цуцлах асуудлыг шүүх шийдвэрлэж байхаар хуульчилсан байна.

**146.** Хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд хамгаалах үүднээс Гэр бүлийн тухай хуулийн 12 дугаар зүйлд “эхнэр нь жирэмсэн буюу хүүхэд нь нэг нас хүрээгүй, эсхүл хариуцагч хүндээр өвчилсөн тохиолдолд гэрлэлтийг цуцлахыг хориглох”-оор заасан бөгөөд мөн



хуулийн 14 дүгээр зүйлд “хүүхдийн нас, эцэг, эхийн халамж, ахуйн нөхцөл, бололцоо, ёс суртахууны байдал, хүчирхийлэл үйлдсэн эсэхийг нь харгалзан хүүхдийг эцэг, эхийн хэн нэгний асрамжид үлдээх, тэтгэлгийн хэмжээг тогтоох, хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг хуваах асуудлыг шүүх шийдвэрлэнэ” гэж хуульчилсан байна. Мөн гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлах нөхцөлд хүүхдийн асрамжийн талаар долоо, түүнээс дээш насны хүүхдийн саналыг харгалзан үзэхээр заасан байна.

**147.** Эрүүгийн хуульд хүндэвтэр, хүнд гэмт хэрэг үйлдсэн жирэмсэн эмэгтэй, түүнчлэн гурав хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн таслан шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болохоор заасан нь хүүхдийн хувийн онцлог байдлыг хүндэтгэсэн төдийгүй гэр бүлийн гишүүдийн үүрэг, хариуцлагыг ижил түвшинд үзэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

**148.** Шүүхийн шийдвэрээр эцэг, эхээс нь салгасан хүүхдийн талаар мэдээлэл алга байна. Эцэг, эх нь шүүхийн шийдвэрээр хорих ял эдлэх нөхцөлд хүүхдийг ихэнхдээ бусад асран хамгаалагч хүлээн авдаг байна.

### **В. Гэр бүлтэйгээ нэгдэх**

**149.** Нийслэлийн цагдаагийн газрын харьяа хүүхдийн халамж үйлчилгээний төв Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран хараа хяналтгүй хүүхдийг гэр бүлд буцаах, тэдний гэр бүлийн амьдрах орчныг сайжруулахад чиглэсэн төслийг тогтмол хэрэгжүүлж байгаагийн дүнд тайлангийн хугацаанд 200 гаруй хүүхдийг гэр бүлд нь буцаажээ.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, холбогдох байгууллагууд хамтран “Монголын үрс–эцэг эхтэйгээ” чуулганы шийдвэрийг хэрэгжүүлж, хараа хяналтгүй байгаа хүүхэд бүрийг гэр бүлийн амьдралд буцаан төлөвшүүлэх бэлтгэл ажлыг эхлээд байна.

### **Г. Эцэг, эх байх эрхийг сэргээх**

**150.** Эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах, эдгээртэй холбоотой үр дагаврыг шийдвэрлэх талаар Гэр бүлийн тухай хуулийн 5 дугаар бүлэгт заасан байна. Энэ бүлэгт эцэг, эх байх эрхийг шүүх хянан үзэх замаар шийдвэрлэхээр заасан байна. Гэхдээ хүүхэд үрчлэгдсэн тохиолдолд эцэг, эх байх эрхийг сэргээхгүй байхаар заажээ.

### **Д. Гэр бүлийн орчноос хөндийрсэн хүүхэд**

**151.** Хүүхдийн эрхийн асуудлаар Монгол Улсад өгсөн дүгнэлт, зөвлөмжийн 34 дүгээр заалтын хүрээнд халамжийн бусад хэлбэрийг хөгжүүлэх, хүүхдийг гэр бүлд нь шилжүүлэх зарим арга хэмжээг хэрэгжүүлж байна. Нийгмийн халамжийн тухай хуулийн 26 дугаар зүйлд түр байрлуулан асрамжлах, гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хүнд нөхцөлд байгаа хүүхдийг хамруулахаар хуульчилсны дагуу зохих стандартуудыг боловсруулаад байна.

Хүүхэд гэр бүлээсээ хөндийрч байгаа шалтгааныг арилгахад чиглэсэн төсөл, хөтөлбөрийг Засгийн газраас олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байна. Хүүхдийн асрамж, халамжийн үйлчилгээний талаар дараагийн бүлэгт танилцуулна. Хүүхдийг түр халамжлах үйлчилгээ

**152.** Гэр бүлийн тухай хуулийн 8 дугаар бүлэгт асран хамгаалах, харгалзан дэмжих, хүүхдийг гэр бүлдээ асран хүмүүжүүлэх харилцааг зохицуулсан байна. Мөн хуулийн 66 дугаар зүйлд бага насны (14 нас хүрээгүй) бүтэн өнчин хүүхэд, эцэг эх нь хоёулаа иргэний эрх зүйн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан хүний бага насны хүүхэд, эцэг, эх нь хоёулаа удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа, хорих газарт ял эдэлж байгаа зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй хүний бага насны хүүхэд, сэтгэцийн өвчний улмаас шүүхээс иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон хүн, бүтэн өнчин ах дүү нарыг асран хамгаалахаар заасан байна.

**153.** Гэр бүлийн тухай хуульд хүнд нөхцөлд байгаа бага насны буюу насанд хүрээгүй хүүхдийг гэр бүлдээ авах замаар өөрийн зардлаар асран хүмүүжүүлэх харилцааг зохицуулсан байна. Хүүхдийг асран хүмүүжүүлэх гэрээ нийгмийн халамжийн байгууллага болон хүсэлт гаргасан иргэний хооронд тодорхой хугацаагаар байгуулна.

Хүүхэд асран хүмүүжүүлэх тухай гэрээнд хүүхдийг асрах, хүмүүжүүлэх, боловсрол олгох нөхцөл, асран хүмүүжүүлэгчийн болон нийгмийн халамжийн байгууллагын эрх, үүрэг, асран хүмүүжүүлэгчид олгох урамшуулал, хууль тогтоомжийн дагуу олгогдох бусад хөнгөлөлт, гэрээ дуусгавар болох үндэслэл, үр дагаврыг тусгажээ.

Хүүхдийг асран хүмүүжүүлэхэд тухайн гэр бүлд тааламжгүй нөхцөл буй болсон нь тогтоогдсон, эцэг, эхэд нь буцаан өгсөн, үрчлүүлсэн бол нийгмийн халамжийн байгууллагын шаардлагаар, хүндэтгэн үзэх бусад шалтгаан (өвчилсөн, гэр бүлийн болон эд хөрөнгийн байдал өөрчлөгдсөн, харилцан үл ойлголцох, маргаантай байдал) буй болсон бол асран хүмүүжүүлэгчийн санаачилгаар гэрээг хугацаанаас өмнө цуцалж болно.

**154.** Хүүхдийг асран хүмүүжүүлэхээр шилжүүлэхдээ долоон наснаас дээш бол өөрийн нь зөвшөөрлийг авах ёстой бөгөөд уг хүүхэд тэжээгчээ алдсаны болон нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авах, хууль тогтоомжийн дагуу орон сууцаар хангагдах эрх эдэлнэ. Асран хүмүүжүүлэгчид олгох урамшуулалд шаардагдах зардлыг Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлнэ.

Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн дүгнэлт, зөвлөмжийн 34 дүгээр заалтын хүрээнд халамж, асрамжийн газрын үйлчилгээний чанарыг сайжруулах, эдгээр байгууллагад төрийн байгууллагын зүгээс тавих хяналтын тогтолцоог бий болгох чиглэлээр Засгийн газраас анхаарч байна. Мөн халамжийн газарт байгаа хүүхдийг гэр бүл, түр асран хамгаалагчийн халамжид шилжүүлэх, эцэг, эхийг чадваржуулах туршилтын ажлыг олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байна.

**155.** Гэр бүлдээ хүүхдийг түр асрамжлах стандартыг боловсруулан Үндэсний стандартчилал, хэмжил зүйн үндэсний зөвлөлөөр батлуулахаар хүргүүлээд байна. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 5 дахь заалтад хүүхдийг сайн дурын үндсэн дээр асран хүмүүжүүлэх гэр бүлд дэмжлэг үзүүлэх гэж заасан боловч түүнийг хэрэгжүүлэх арга зам тодорхой бус хэвээр байна. Мөн хуулийн 71 дүгээр зүйлд асран хамгаалах, харгалзан дэмжвэл зохих хүний талаарх мэдээллийг хүлээн авах, нөхцөл байдлыг судалсны үндсэн дээр шийдвэр гаргах, асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоогдоогүй нөхцөлд хүүхдийг хүүхэд асран хүмүүжүүлэх газарт шилжүүлэх шийдвэр гаргах, асрамж, дэмжлэгт байгаа хүүхэд нэг бүрт хувийн хэрэг нээж хөтлөх,

түүнд шаардлагатай материалыг хавсаргах, баяжилт хийх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нартай нэг бүрчлэн гэрээ байгуулан хэрэгжилтийг хянах, шалгах үүргийг сум, дүүргийн Засаг дарга хүлээхээр заасан байна.

**156.** Монгол Улсад 2006 оны байдлаар 5276 бүтэн өнчин хүүхэд байна. Тэдний 2000 гаруй хүүхэд бусдын асран хамгаалалтад, 500 гаруй хүүхэд асрамжийн газарт, бусад хүүхэд нь халамжийн газруудад байгаа мэдээлэл байна. Түүнчлэн бүтэн өнчин хүүхдээс бусад нөхцөлд байгаа, ялангуяа ашиг сонирхол зөрчигдсөн болон хараа хяналтгүй, орон гэрээсээ дайжсан хүүхдийг түр хамгаалалд авах практик байхгүй байна.

### **Е. Үрчлэлтийн тогтолцоо**

*(21 дүгээр зүйл)*

**157.** Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн дүгнэлт, зөвлөмжийн 36 дугаар заалтыг дэмжин ажиллаж байна. Энэ хүрээнд Монгол Улсын дотоод болон гадаад үрчлэлтийн тогтолцоо, эрх зүйн зохицуулалтыг нэмж тайлбарлаж байна.

**158.** Гэр бүлийн тухай хуулийн 7 дугаар бүлэг бүхэлдээ хүүхдийг тэдний ашиг сонирхлын үүднээс үрчлүүлэх харилцааг зохицуулж байна. Энэ үйл ажиллагаа хүүхдээ үрчлүүлэх тухай эцэг, эхийн, бүтэн өнчин хүүхэд, түүнчлэн эцэг, эх нь хоёулаа иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй бол тухайн хүүхдийн асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагын зөвшөөрлийг тус тус авах ёстой. Харин долоон нас хүрсэн хүүхдээс өөрийн нь зөвшөөрлийг авна.

**159.** Ердийн нөхцөлд хүүхэд үрчлэн авахыг хүсэгч нь хүүхдийн оршин суугаа сум, дүүргийн Засаг даргад хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтээ гаргах ба сум, дүүргийн Засаг дарга хүсэлтийг хянан үзэж, үрчлүүлэх эсэх тухай шийдвэрийг 20 хоногт багтаан гаргана. Хүүхэд үрчилсэн тухай шийдвэрийг үндэслэн иргэний гэр бүлийн бүртгэлийн ажилтан хүүхэд үрчилснийг бүртгэнэ.

Хүүхдийн эрхийн хорооны дүгнэлт, зөвлөмжийн 36 дугаар заалтын хувьд хүүхэд үрчлүүлэх шийдвэр гаргах мэргэжлийн баг, байгууллагын талаар ямар нэг нэмэлт, өөрчлөлт хийгээгүй байна. Тухайн шатны Засаг даргын санаачилгаар ийм үүрэг бүхий албан бус ажлын хэсгийг ажиллуулах боломжтой юм.

**160.** Гэр бүлийн тухай хуулийн 56 дугаар зүйлд хүнд нөхцөлд байгаа үрчлүүлэх хүүхдийн судалгааг сум, дүүргийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд гаргаж, бүртгэл хөтлөх, түүнчлэн хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүнд нөхцөлд байгаа үрчлүүлэх хүүхдийн нэгдсэн бүртгэл хөтөлж, хяналт тавихаар заасан байна.

**161.** Үрчлэгч нь насанд хүрсэн, иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжтай, хүүхдийг тэжээн тэтгэж, өсгөн хүмүүжүүлэх зохих боломжтой хүн байна. Мөн 60–аас дээш настай, эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан буюу хязгаарлуулж, хасуулж байсан, урьд нь үрчлэн авсан хүүхдээ өөрийн буруугаас буцаан өгсөн, ашиг хонжоо олох зорилготой, шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон, сүрьеэ, сэтгэцийн өвчтэй, согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэдэг, эрүүгийн хэрэгт удаа дараа шийтгүүлсэн болон хорих ял эдэлж

байгаа хүнд хүүхэд үрчлүүлэхийг хориглосон байна. Гэхдээ насны хязгаарлалт нь бүтэн өнчин хүүхдийг төрөл, садангийн хүн нь үрчлэн авахад үл хамаарахаар хуульчилсан байна.

**162.** Үрчлэн авагч хүүхэд үрчлэн авах тухай өргөдлөө (өргөдөлд хүүхдийн овог, эцгийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр, төрсөн эцэг, эх, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн болон үрчлэн авагчийн овог, эцгийн нэр, нэр, оршин суугаа газрын хаяг, шаардлагатай бол аль улсын харьяат болохыг дурдсан байна) хүүхдийн оршин сууж байгаа буюу урьд оршин сууж байсан газрын сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт гаргах бөгөөд хүүхдийг үрчлэн авсан тухай иргэний гэр бүлийн бүртгэлд бүртгэнэ.

**163.** Үндэсний статистикийн газрын мэдээллээр 2004 онд 1861, 2005 онд 3797, 2006 онд 2045 хүүхдийг үрчилсэн байна. Тайлант хугацаанд нийт 7703 хүүхэд үрчлэгдсэний 36.8 хувь нь 0–3 хүртэл насны, 23.7 хувь нь 3–6 насны, үлдсэн 39.5 хувь нь 6–18 хүртэл насны хүүхэд байна.

**164.** Үрчлэгдсэн хүүхдийн амьдарч байгаа орчин нөхцөл, хөгжилд харьяа засаг захиргааны нэгжийн Засаг дарга хяналт тавихаар хуульчилсан байдаг хэдий ч хэрэгжилтийн талаар ямар нэг мэдээлэл алга байна.

**165.** Гэр бүлийн тухай хуулийн 58 дугаар зүйл бүхэлдээ гадаадын иргэн хүүхэд үрчлэх харилцааг зохицуулахад чиглэсэн байна. Түүнчлэн 1993 оны Гаагийн хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенцид Монгол Улс 1999 онд нэгдэн орсон байна. Энэхүү эрх зүйн баримт бичгийн хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2001 оны 100/32 дугаар хамтарсан тушаалаар “Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журам”-ыг баталж мөрдүүлсэн байна.

**166.** Гадаадын иргэн хүүхэд үрчлэн авах хүсэлтээ өөрийн орны эрх бүхий байгууллагаар дамжуулан Монгол Улсын эрх бүхий байгууллагад гаргана. Гэхдээ Монгол Улсад зургаан сараас доошгүй хугацаанд оршин сууж байгаа гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авахад болон гадаад улсад оршин суугаа Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэн авах хүсэлтээ Монгол Улсын дипломат болон консулын байгууллагаар уламжлахад энэ заалт хамаарахгүй болно.

**167.** Хүүхэд үрчлэхийг хүссэн гадаадын иргэн хүүхэд үрчлэн авахыг хүсэгчийн (нөхөр, эхнэртэй бол хамтарч гаргасан) хүсэлт, түүний нотариатаар гэрчлүүлсэн албан ёсны орчуулга, түүнчлэн сүрьеэ, ДОХ, сэтгэцийн өвчтэй эсэх талаарх эмнэлгийн магадлагаа, гэрлэлтийн гэрчилгээний хуулбар, өргөдөл гаргагчийн байнга оршин суугаа газрын талаар холбогдох байгууллагын тодорхойлолт, амьдралын болон санхүүгийн боломжийн тухай тухайн улсын холбогдох байгууллагын тодорхойлолт, өргөдөл гаргагчийн талаарх хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тодорхойлолт зэрэг бичиг баримтыг бүрдүүлсэн байхаар заасан байна.

**168.** Хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах хүсэл гаргасан гадаадын иргэний бүртгэл хөтөлж, хүүхдийг үрчлэх, үрчлэгдсэн хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах асуудлаар бусад улс, тэдгээрийн холбогдох байгууллага, олон улсын байгууллагатай хамтран ажиллаж байна.

Хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад Гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэх асуудлаар дүгнэлт гаргах зөвлөл ажилладаг бөгөөд энэ зөвлөл хүүхдийг судлах, санал болгох, дүгнэлт гаргах, үрчлэгдсэн хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах асуудлыг хариуцан ажиллаж байна. Энэ зөвлөлөөс гаргасан саналыг үндэслэн гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлэх эцсийн шийдвэрийг Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны Захирлын зөвлөл гаргадаг.

Иргэний бүртгэл мэдээллийн улсын төв гадаадын иргэнд үрчлүүлсэн хүүхдийг бүртгэж гурван төрлийн гэрчилгээ олгодог. Хүүхдээ үрчлүүлсэн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүүхэд үрчлүүлсний гэрчилгээ олгоно.

Хүүхэд үрчлүүлсний гэрчилгээнд хүүхдийн овог, эцгийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр, хүйс, төрсөн газар, үрчилж авсан болон үрчлүүлсэн эцэг, эх, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн овог, эцгийн нэр, нэр, үрчилсний бүртгэл үйлдсэн газрын нэр, гэрчилгээний дугаар, үрчилсний бүртгэл үйлдсэн он, сар, өдөр, албан тушаалтны гарын үсэг, тамга, тэмдэг зэргийг тусгана.

**169.** Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэн авах тухай гадаадын иргэнээс гаргасан хүсэлтийг хилийн чанад дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар энэ хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

**170.** Үрчилсний бүртгэлийг хүүхдийн төрснийг бүртгэснээс өөр газар бүртгэсэн бол иргэний бүртгэлийн ажилтан уг бүртгэлд өөрчлөлт оруулах тухай мэдэгдлийг хүүхдийн төрснийг бүртгэсэн сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт хүргүүлнэ. Үрчлэлтийг хүчингүй болсонд тооцсон тухай шүүхийн шийдвэрийг үндэслэн иргэний бүртгэлийн ажилтан уг бүртгэлд өөрчлөлт оруулж төрсний гэрчилгээг сэргээж, төрсөн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид олгоно.

**171.** Монгол Улс нь 2005 онд 20 хүүхэд, 2006 онд 27 хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлсэн байна. Эдгээр хүүхдийн тэн хагас нь эмэгтэй хүүхэд байна. Нийт 47 хүүхдийн 90 гаруй хувь нь 0–3 насны хүүхэд байгаа бөгөөд АНУ–ын иргэд 27 хүүхдийг, Франц улсын иргэд 6 хүүхдийг үрчилсэн бол ХБНГУ, Англи, БНСУ зэрэг улсын иргэд 14 хүүхдийг үрчилж авсан байна.

**172.** Монгол Улс гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх асуудлаар 6 улс оронтой хамтран ажиллаж байна. Дани, Голланд зэрэг орны хүүхэд үрчлэлийн төв байгууллагатай шууд, Итали, Герман, Франц, АНУ–ын хүүхэд үрчлэлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий төрийн бус байгууллагын итгэмжлэгдсэн этгээдтэй хамтран ажиллаж байна.

**173.** Хүүхдийг хамгаалах, улс хооронд үрчлэх асуудлаар үүрэг гүйцэтгэж байгаа байгууллагуудын чиг үүрэг тодорхой бусаас үйл ажиллагаа явуулах эрх авах, бүртгүүлэх, уламжилсан хүсэлтээ шийдвэрлүүлэхээр холбогдох төрийн захиргааны байгууллагыг гурван жил хүлээсэн нэг байгууллага арга буюу үйл ажиллагаагаа зогсоож, төлөөлөгчийн газраа хаасан байна.

**174.** Гадаадын иргэнд үрчлүүлсэн хүүхдийн байдалд төрөөс тавих хяналтын тогтолцоо хангалтгүй хэвээр байна. Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх тухай журамд зааснаар Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба (Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг)

тодорхой хугацаанд хүүхдийн талаарх тайланг авах, үрчлэгдсэн хүүхдийн оршин суух газрыг харьяалах Монгол Улсын дипломат төлөөлөгчийн, эсвэл консулын газарт хүүхэд үрчлэгдсэн тухай мэдээлэх, үрчлэгдсэн хүүхдийн байдалд иргэний нийгмийн итгэмжлэгдсэн төлөөлөөр хяналт тавьж болох тухай заасан байдаг.

Гэвч зурагтай, цөөн хуудастай тайлан хүлээн авахаас хэтрэхгүй байгаад энэ ажлыг хариуцсан төрийн захиргааны байгууллагууд дүгнэлттэй хандаж, түүнийг сайжруулах чиглэлээр судалж байна.

**Ё. Хүүхдийг хууль бусаар эх орноос нь шилжүүлэх буюу  
гадаад улсаас эх оронд нь буцаахгүй байх**

*(11 дүгээр зүйл)*

**175.** Хүүхдийн хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсвэл эцэг, эх биш бол хүүхдийг хил дамжуулан гаргах эрхгүй. Тиймээс хилээр хүүхэд дагуулан гаргаж буй хүн бүрийн “албан ёсны эцэг, эх, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч мөн” болох эсэх тухай баримт бичгийг шалгах журамтай байдаг.

Эмчлүүлэхээр хил гарах тохиолдолд хүүхдийг эмчлүүлэхийг дэмжсэн Эрүүл мэндийн яамны тодорхойлолтыг авсан байна. Энэ хоёр төрлийн баримт бичгийг хилийн шалган нэвтрүүлэх боомт заавал шалгах болсон юм.

**176.** Монгол Улсын хилээр орох, гарах мэдүүлэгт дагалдан яваа хүүхдийн тухай мэдээллийг оруулсан нь хилээр нэвтэрсэн хүүхдийг бүртгэх боломж олголоо. Гэхдээ гадаад оронд амьдарч байгаа, эх орондоо буцаж ирсэн хүүхдийн талаар статистик мэдээлэл одоогоор алга байна.

**177.** Гадаадад амьдарч байгаа болон гадаадын иргэдтэй гэр бүл бологчдын хүүхдийн харьяалал, хамгааллыг шийдвэрлэхэд төвөгтэй асуудал гарч байна.

**Ж. Хүчирхийлэл, үл хайхрах явдлаас хамгаалах**

**178.** Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн дүгнэлт, зөвлөмжийн 38 дугаар заалтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд явагдаж байна.

**179.** Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1–д Засгийн газар гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаарх бодлого, хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэхээр заасны дагуу Засгийн газар 2007 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөрт гэр бүлийн гишүүд хүчирхийллээс ангид амар амгалан, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гэр бүлийн харилцаанд хүчирхийллийн бус арга, хэлбэрийг нэвтрүүлэх замаар хүний эрх, эрх чөлөөг хангаж, гэр бүлийн хүчирхийлэл үүсэн гарч байгаа шалтгаан нөхцөл болон нийгмийн сөрөг үзэгдлийг арилгах зорилго, тэргүүлэх чиглэл, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан болно.

**180.** Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг таслан зогсоох арга хэмжээг шуурхай авах, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх харилцааг зохицуулж байна.

Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан аль нэг этгээд нөгөө этгээдийн эрх, эрх чөлөөг зөрчиж гэм хор учруулсан, эсхүл учруулахаар заналхийлсэн эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй үйлдэл, эс үйлдэхгүйг гэр бүлийн хүчирхийлэл гэж томьёолсон бөгөөд энэ нь бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн, эдийн засгийн хэлбэртэй байж болно гэж заажээ. Мөн гэр бүл гэсэн ойлголтод Гэр бүлийн тухай хуульд заасан гэр бүлийн гишүүн, төрөл садан багтаж байна. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчдыг хамгаалах талаарх БНСУ, Филиппин улсын хууль эрх зүйн орчинтой танилцаж, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн гишүүдийг хамгаалах, зөвлөгөө өгөх, хамгаалах байраар хангах үйл ажиллагааны зохион байгуулалт, эдгээр үйлчилгээний цогц стандартыг боловсруулан гаргасан ажлын туршлагыг судалж байна.

**181.** Хууль зүй, дотоод хэргийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахаас гадна гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрийг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж, мөрдүүлэх үүргийг хүлээж байна.

**182.** Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны бүх шатны байгууллага өөрийн нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, дэмжих, эдгээр үйл ажиллагааг санхүүжүүлэх үүргийг хүлээж ажилладаг. Хэрэгжүүлэх чиг үүргийг цагдаагийн байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан болон төрийн бус байгууллагууд хүлээж байна. Гэр бүлийн болон бусад хэлбэрийн хүчирхийлэлтэй тэмцэх үүрэг бүхий байгууллагуудын ажлын уялдаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, чадваржуулах хэрэгцээ байсаар байна.

**183.** Цагдаагийн байгууллага гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг таслан зогсоох зорилгоор гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гомдол хүлээн авах, бүртгэх, хүчирхийлэл үйлдэгдсэн газарт хүрэлцэн очиж хохирогч, хүчирхийлэл үйлдэгч болон гэрчээс асууж, тэмдэглэл хөтлөх, шаардлагатай бусад ажиллагаа явуулах, хохирогчид түүний эдлэх эрх болон хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авахуулахаар шийдвэр гаргуулах журмын талаар тайлбарлаж өгөх, хүчирхийлэл үйлдэгчид захиргааны болон эрүүгийн шийтгэл ногдуулж болох тухай сануулах, шаардлагатай тохиолдолд хохирогчийг эмнэлэгт, эсхүл хамгаалах байранд хүргэх, боломжтой бол төрөл, садангийн хүний түр хамгаалалтад өгөх, шаардлагатай гэж үзвэл хүчирхийлэл үйлдэгчийг хууль тогтоомжийн дагуу захиргааны журмаар албадан саатуулах, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг хууль тогтоомжийн дагуу эрүүлжүүлэх байранд хүргэх, хохирогчийг шаардлагатай үйлчилгээнд хамруулах талаар нийгмийн ажилтанд мэдэгдэх, хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлтээ эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргах үүргийг хүлээж байна.

**184.** Сум, хорооны нийгмийн ажилтан тухайн гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлын талаар үнэлгээ өгөх, орчны сөрөг нөлөө, аюулын зэргийн түвшинг цагдаагийн ажилтантай хамтран тогтоох, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг цагдаагийн байгууллагатай хамтран зохион байгуулж, хохирогчид үзүүлэх үйлчилгээ, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн

сургалт, сурталчилгааг энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагын туслалцаатайгаар явуулах, хохирогчид үзүүлсэн үйлчилгээний талаар тайлан мэдээ гаргаж, гэр бүлийн хүчирхийллийн холбоотой мэдээллийн сүлжээ бий болгох үүргийг хүлээж байна.

Хүчирхийлэл үйлдсэн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй гол мэргэжилтэн бол нийгмийн ажилтан юм. Боловсролын нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолтод хүүхэд хамгаалах эрх, үүргийг тодотгосон заалтуудыг нэмж оруулсан болно. Их Британий Хүүхдийг ивээх сангийн дэмжлэгээр нийгмийн ажилтан бэлтгэдэг сургуулийн Хүүхэд хамгааллын хичээлийн агуулга, хөтөлбөрийг боловсруулж хоёр сургуульд амжилттай туршсаны дагуу 2007/2008 оны хичээлийн жилээс нийгмийн ажилтан бэлтгэдэг бүх сургуульд энэ хичээлийг зааж эхэлсэн байна.

**185.** Гэр бүлийн ба бусад хүчирхийллийн асуудлаар захиргааны болон эрүүгийн хариуцлага ногдуулахаар хуульчилсан байна. Хууль батлагдсанаас хойших хугацаанд улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой арван есөн хэргийг шүүх хянан шийдвэрлэсэн байна.

**186.** Хууль зүй, дотоод хэргийн яамнаас иргэдэд зориулан гаргасан эрх зүйн албан бус сургалтын сурах бичигт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар тусгайлсан бүлэг оруулсан бөгөөд энэхүү номыг нийт аймаг, дүүрэг, сум, хорооны Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн байна. Хууль зүй, дотоод хэргийн яам “Тэгш эрхийг хангах цогц бодлого” сэдэвт сургалт-семинарын хүрээнд “Гэр бүл дэх хүүхдийн эсрэг хүчирхийлэл” гэсэн илтгэлийг хэлэлцүүлж, түүнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байгууллагын анхан шатны нэгжийн ажилтнуудыг хамруулан сургасан байна.

**187.** Улсын дээд шүүхээс Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарласан тайлбарыг батлан гаргасан нь хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэхэд тус дөхөм боллоо.

**188.** Хэдийгээр хууль эрх зүйн орчин бүрдэж эхэлсэн боловч Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна<sup>3</sup>. Тодорхой хүрээнд хийсэн судалгаагаар манай улсын хүн амын 20 орчим хувь буюу таван гэр бүл тутмын нэг нь хүчирхийллийн ямар нэгэн харилцаатай [1], гурван эмэгтэй тутмын нэг нь ямар нэгэн хэлбэрийн хүчирхийлэл, дарамтын дор байдаг, хүчирхийлэгчдийн 95 хувь нь эрэгтэйчүүд байдаг [2], гэр бүл салалтын 41.3 хувь нь хүчирхийллийн улмаас салсан [3] гэсэн тоо баримт гарсан нь гэр бүлийн хүчирхийлэл нийгмийн тулгамдсан асуудлын нэг болсныг бодитой илэрхийлж байна.

Түүнчлэн судалгаанд оролцсон хүүхдийн 55 хувь нь бусдын дарамт, хүчирхийллийг ямар нэг хэмжээгээр амсдаг [5] гэж хариулсан байна. Хүчингийн гэмт хэргийн 26.6 хувийг ураг төрлийн хүчин эзэлж байгаа бөгөөд хохирогчийн 60 хувь нь 5–18 хүртэл насны охид байна. Бага насны охид ураг төрлийн хүчингийн золиос болох тохиолдол жил тутам нэмэгдэж байгаа ч хуулийн байгууллагад бүртгэгдсэн ийм төрлийн гэмт хэргийн 88 хувь нь шүүхийн өмнөх шатанд хэрэгсэхгүй болж байна<sup>4</sup>.

<sup>3</sup> Хүний эрх улирал тутмын сэтгүүл, 2006/3 хуудас 38–44

<sup>4</sup> Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба хууль эрх зүйн орчин, ХЭХТ, ХЭҮТ, ЭЯГБХУТКХХТ, 2002



**189.** Ураг төрлийн хүчирхийллийн асуудлаар хуулийн хэрэгжилт хангалтгүй хэвээр байна.

**190.** Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн дүгнэлт, зөвлөмжийн 38 дугаар зүйлийн “б” – д заасан хүүхдийн хүчирхийллийн учир шалтгааны хүрээг судлах, зөвлөмжийн дагуу “Хүүхдийн бие махбод, сэтгэл санааны эсрэг шийтгэл, хүүхдийн үзэл бодол”<sup>5</sup>, “Хүнд нөхцөл дэх хүүхдийн амьдрал” зэрэг судалгааг явуулсан байна.

“Хүүхдийн бие махбод, сэтгэл санааны эсрэг шийтгэл, хүүхдийн үзэл бодол” судалгаанд 6–15 насны 595 хүүхэд оролцсон бөгөөд тэдний 42 хувь нь гэр бүлийн орчинд шийтгэл хүлээдэг гэж хариулсан байна. Хүүхдүүд хичээлээ давтаагүй, үгэнд ороогүй, буруу хэрэг хийсэн гэсэн шалтгаанаар шийтгэл хүлээдэг гэж хэлжээ.

Мөн Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, НҮБ-ын Хүүхдийн сан, Хүний эрхийн Үндэсний Комисс, Монгол Улсын Боловсролын их сургууль хамтран “Сургууль, цэцэрлэгийн орчин дахь хүүхдийн эсрэг хүчирхийлэл, түүнийг арилгах арга зам” сэдэвт судалгааг 2007 оны 5–6 дугаар сард явуулж, энэ судалгааны дүнг олон нийтэд хүргэсэн байна.

**191.** Гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төвүүд зарим аймаг, дүүрэгт үр дүнтэй ажиллаж байна. Эдгээр байгууллага төлбөргүй үйлчилгээ үзүүлж, гэр бүл судлаач мэргэжлээр 2007 онд 25 хүнийг анх удаагаа бэлтгэн гаргалаа.

**192.** Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар өөрийн харьяа бүх байгууллагад нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарыг ажиллуулж байна. Гэр бүлийн хүчирхийлэл болон бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой хэргийг мөрдөх, байцаан шийтгэх, хүчирхийлэл үйлдэгчэд ял ногдуулах хууль эрх зүйн үйл ажиллагаа хүүхдэд мэдрэмжтэй, хүүхдийн язгуур эрх ашгийг нэн тэргүүнд харгалздаг байхын тулд аймаг, дүүргийн цагдаагийн байгууллагуудад сэтгэлзүйч нарыг ажиллуулж эхэллээ.

Хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд нөхөн сэргээх, нийгмийн амьдралд буцаан оруулах арга хэмжээ хамаарах

**193.** Олон нийтэд түшиглэсэн нийгмийн үйлчилгээ, нөхөн сэргээх үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр Засгийн газар зарим нэг арга хэмжээг хэрэгжүүлж байна.

**194.** Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам 2004 оноос жил бүр Гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллаж байна. Түүнчлэн Улаанбаатар хотоос гадна Төв, Сэлэнгэ, Дундговь аймагт хамгаалах байрыг олон улсын байгууллагуудын санхүүгийн дэмжлэгтэйгээр байгууллаа. Сэтгэл зүйн болон нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, архи, гаж зуршлын эмчилгээ эрхлэх олон нийтийн болон бизнесийн байгууллага олноор ажиллах боллоо.

**195.** Хүчирхийлэлд өртсөн хүмүүсийг хамгаалах байранд эмнэлгийн тусламж үзүүлэх, хууль зүйн зөвлөлгөө өгөх, нөхөн сэргээх болон сэтгэл заслын үйлчилгээг явуулах хамтын ажиллагааны гэрээг Хүчирхийллийн эсрэг үндэсний төв Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамтай байгуулан 2006 онд 6.0 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх хамгаалах төв (байр)

<sup>5</sup> Их Британий Хүүхдийг ивээх сан. Хүүхдийн бие махбод, сэтгэл санааны эсрэг шийтгэл, хүүхдийн үзэл бодол, 2005

байгуулагдсанаар хүүхэд мэргэжлийн үйлчилгээ авах боломжтой боллоо.

**196.** Хүүхдийг хүчирхийллээс хамгаалах төв төрийн бус байгууллага хүчирхийлэлд өртсөн хүүхдэд сэтгэлзүйн зөвлөгөө өгөх, хүчирхийлэлд өртөж байгаа хүүхдийн талаар мэдээлэл авах, хүчирхийлэл болон хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргын талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх, хүүхэд хамгааллын яаралтай тусламжийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор “Дотно яриа-464060” дугаарын утас ажиллуулж байна.

Хүчирхийлэл дарамтад өртсөн нийт 237 хүүхдэд 2006 онд утсаар болон биечлэн сэтгэл зүйн зөвлөгөө өгч, 29 хүүхдэд кэйс менежментийн үйлчилгээг амжилттай үзүүлсэн байна. Энэ сүлжээг санаачлагч, зохицуулагч байгууллага болох Хүүхдийг хүчирхийллээс хамгаалах төв хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажиллахаас гадна сүлжээний байгууллагуудын цогц үйлчилгээний зохицуулагчийн үүрэг гүйцэтгэж байна. *Тухайлбал*, Эх, нялхсын эрдэм шинжилгээний төвийн эрүүл мэндийн, Цагдаагийн ерөнхий газрын хүүхэд хамгааллын яаралтай тусламжийн, Нийслэлийн хүүхэд, залуучуудын газрын нийгмийн хамгааллын, Нийслэлийн цагдаагийн газрын эрх зүйн тусламжийн, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн хамгаалах байрны үйлчилгээ үзүүлэх ажлыг тус тус уялдуулан зохицуулж байна.

**197.** “Хүүхдийн эсрэг хүчирхийлэл” сэдвээр хүүхдийн эрхийн сэтгүүлч, хүүхдийн зуслангийн багш, хүүхдийн эмч, нийгмийн ажилтан нарт сургалт явуулж, гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн тухай судалгаа хийж, улмаар олон нийтэд зориулсан сурталчилгааны материалыг ээлтгэн түгээх ажлыг гадаад, дотоодын төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж байна.

**198.** Сүүлийн жилүүдэд хүүхэд, өсвөр үеийнхний дунд сэтгэл зүйн бухимдлын үр дагавар болох мэдрэлийн өвчин, зан үйлийн эмгэг, хорт зуршилд автах, амиа хорлох, гэрээсээ дайжих зэрэг сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал элбэг тохиолдох боллоо.

Судалгаанаас үзэхэд 10–18 насны өсвөр үеийнхэн бүх төрлийн гадуурхалд илүү өртөж байгаа бөгөөд тэдний 67.8 хувь нь ганцаарддаг төдийгүй дийлэнхийг нь охид эзэлж, улмаар хотын хүүхэд хөдөөний хүүхдээс илүүтэй сэтгэл зүйн хямралд өртөж байна.

### **3. Асрамж, халамжийн нөхцөл байдлыг тогтсон хугацаанд үнэлж, дүгнэх**

**199.** Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн дүгнэлт, зөвлөмжийн 34 дүгээр зүйлийн хүрээнд халамж, асрамжийн газрын үйлчилгээний чанарыг сайжруулах, эдгээр байгууллагад төрийн байгууллагын зүгээс тавих хяналтын тогтолцоог бий болгох чиглэлээр Засгийн газраас анхаарч байна. Мөн халамжийн газарт байгаа хүүхдийг гэр бүл, асран хамгаалагчийн халамжид шилжүүлэх, эцэг, эхийг чадваржуулах туршилтын ажлыг олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байна.

**200.** Халамж үйлчилгээ шаардлагатай хүүхдийг санаачилгаараа гэр бүлдээ түр асрамжлах үйлчилгээний стандартын төслийг боловсруулж, улмаар Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн даргын зөвлөлөөр хэлэлцүүлж байна.

**201.** Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалтад “хүүхдийг сайн дурын үндсэн дээр асран хүмүүжүүлэх гэр бүлд дэмжлэг

үзүүлэх” гэж заасан боловч түүнийг хэрэгжүүлэх арга зам тодорхой бус хэвээр байна.

Гэр бүлийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд асран хамгаалах, харгалзан дэмжвэл зохих хүний талаарх мэдээллийг хүлээн авах, нөхцөл байдлыг судалсны үндсэн шийдвэр гаргах, асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоогдоогүй нөхцөлд хүүхдийг хүүхэд асран хүмүүжүүлэх газарт шилжүүлэх шийдвэр гаргах, асрамж, дэмжлэгт байгаа хүүхэд нэг бүрт хувийн хэрэг нээж хөтлөх, түүнд шаардлагатай материалыг хавсаргах, баяжилт хийх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нартай нэг бүрчлэн гэрээ байгуулж, биелэлтийг шалгах үүргийг сум, дүүргийн Засаг дарга нарт хүлээлгэсэн байна.

**202.** Хүүхдийн асрах үйлчилгээнд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ, сувилал, асран хүмүүжүүлэх, гэр бүлд чиглэсэн үйлчилгээг хамруулан үзэж байна. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний талаар тайлангийн долоодугаар бүлэгт, сувиллын болон асран хүмүүжүүлэх газрын үйл ажиллагааны талаар эрүүл мэнд ба нийгмийн халамжийн талаарх зургадугаар бүлэгт дэлгэрэнгүй танилцуулах болно.

**Конвенцийн 11, 18, 21 дүгээр зүйлийн дагуу хоёр болон олон талт гэрээ хэлэлцээр, конвенцийн талаарх мэдээлэл, эдгээрийн хүүхдэд үзүүлж буй нөлөөлөл**

**203.** Монгол Улс “Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, садар самууныг сурталчлахын эсрэг нэмэлт протокол”–д нэгдэн орсон бөгөөд “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тухай” НҮБ–ын нэмэлт протоколд нэгдэн орохоор ажиллаж байна. Түүнчлэн хүний наймаанаас сэргийлэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлийн сургалтыг Швед Улстай хамтран зохион байгуулж байна. ОХУ, Хятад Улстай мансууруулах бодисын эргэлтэд хяналт тавих чиглэлээр хамтран ажиллаж байна.

**204.** Хүүхдийг биеэ үнэлэх, садар самуунд сурталчлах, бэлгийн мөлжлөгт татах, дамжуулан худалдаалах явдлыг устгах чиглэлээр хамтран ажиллах олон улсын сүлжээ (ЭКПАТ)–нд 2004 онд элсэн орсон бөгөөд энэ чиглэлийн үндэсний сүлжээнд төрийн ба төрийн бус, олон улсын 20 гаруй байгууллага нэгдэн ажиллаж байна.

Үндэсний сүлжээ нь хүчирхийллийн талаарх судалгааг явуулахад оролцож хүүхдийг худалдах, садар самуун явдал, бэлгийн мөлжлөгт өртөхөөс хамгаалах үндэсний хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд Дэлхийн зөн олон улсын байгууллага 2005 оноос Монгол Улсад хүүхэд, эмэгтэйчүүдийг зүй бусаар ашиглах, худалдаалах явдлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэмцэх тогтолцоог бий болгоход нөлөөлөх төслийг хэрэгжүүлж байна.

**Зургаадугаар бүлэг. Эрүүл мэнд ба нийгмийн халамж**

*(6, 18 дугаар зүйлийн 3–р заалт, 23, 24, 26 ба 27 дугаар зүйлийн 1–3 дугаар заалт)*

**205.** Хүүхдийн эрүүл мэнд ба нийгмийн халамжийн асуудлыг үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулсан мэдээллийг Монгол Улсын үндэсний хоёрдугаар илтгэлийн хоёрдугаар бүлэгт буюу 6–7 дахь талд танилцуулсан болно.

**206.** Энэ хэсэгт Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн дүгнэлт, зөвлөмжийн 44, 46, 48 ба 50 дугаар заалтын хүрээнд авсан арга хэмжээний талаар дэлгэрэнгүй танилцуулсан болно.

**207.** Монгол Улсын Засгийн газар хөдөөгийн малчдын болон нийгмийн эмзэг бүлэгт амьдарч буй хүүхдийн эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулахад ихээхэн анхаарч ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газраас тэдний эрүүл мэндийг хамгаалахтай холбоотой “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Хүүхдийн өвчний цогц менежмент”, “Сумын эмнэлгийн хөгжил”, “Эрүүл мэндийн технологийг сайжруулах” зэрэг хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Түүнчлэн Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай, Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний тухай хуулийг шинээр батлуулж, Эрүүл мэндийн тухай хуульд зарим нэмэлт, өөрчлөлт оруулах арга хэмжээ авлаа.

**208.** Эрүүл мэндийн тухай хуульд төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага эх, хүүхдэд үнэ төлбөргүй үйлчлэх нэмэлт оруулсны зэрэгцээ Монгол Улсын иргэнд түүний эрүүл мэндийн даатгалд даатгуулсан эсэхээс үл хамааран нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүрээнд дараахь эрүүл мэндийн тусламжийг үнэ төлбөргүй үзүүлж байна. *Тухайлбал,*

Эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийн үйлчилгээ;

Сүрьеэ, хорт хавдар, сэтгэцийн эмгэгийн эмчилгээ, халдвар судлалын үйлчилгээ, төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх тарилга, халдварт өвчний голомтын ариутгал, халдваргүйтгэл;

Жирэмсэн, төрөх, төрсний дараахь үед эмнэлгийн заалтаар хийлгэсэн үзлэг, шинжилгээ, эмчилгээ;

Байгалийн гамшиг, гэнэтийн аюул, осол болон нийтийг хамарсан аюул бүхий халдварт өвчний дэгдэлтийн үед гэмтсэн, өвчилсөн хүний эмчилгээ;

Аргагүй хамгаалалт, гарцаагүй байдалд хүний амь нас аврахаар, эсхүл их хэмжээний хохирлоос сэргийлж яваад гэмтсэн, өвчилсөн хүний эмчилгээ;

Удаан хугацааны нөхөх эмчилгээ шаардах эмгэгийн болон хөнгөвчлөх эмчилгээний зарим эмийн зардал;

Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ зэрэг болно.

**209.** Монгол Улсын эмнэлгийн тусламж, үйлчилгээ гурван шатлалт тогтолцоотой билээ. Анхдагч шатлалын тусламж, үйлчилгээг өрхийн болон сум, сум дундын эмнэлэг; хоёрдогч шатлалын тусламж, үйлчилгээг аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг; гуравдагч шатлалын тусламж, үйлчилгээг клиникийн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн төвүүд тус тус үзүүлж байна.

Монгол Улсад 2006 оны байдлаар Улаанбаатар хотын нэг сая гаруй хүн амд өрхийн эмнэлэг 224 үйлчилж, тэнд 730 их эмч, 731 сувилагч ажиллаж байна. Сумын нийт 228, сум дундын 34 эмнэлэг үйлчилж байна. Сумын 143 эмнэлэг нь нэг их эмчтэй, 99 эмнэлэг нь хоёр их эмчтэй, 9 эмнэлэг нь гурваас дээш эмчтэй байхад 15 эмнэлэг нь их эмчгүй байна. Түүнчлэн цөөнгүй сум цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй учир эх, хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх магадлал өндөр байна.

Анхлан 2001 онд баталсан “Сумын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны улсын стандарт”-ын дагуу сумын эмнэлгийг үйлчлэх хүрээний хүн амын тооноос хамааруулан гурван зэрэглэлд хуваасан байна. Сумын 1-р зэрэглэлийн эмнэлэг 4500-гаас дээш хүн амд үйлчилж 7-гоос дээш их эмч ажиллах; сумын 2-р зэрэглэлийн эмнэлэг 3001-4500

хүртэл хүн амд үйлчилж 3–аас дээш их эмч ажиллах; сумын 3–р зэрэглэлийн эмнэлэг 3000 хүртэл хүн амд үйлчилж 1 их эмч ажиллахаар норматив тогтоосон байна.

Өнгөрсөн 2006 оны байдлаар эмнэлгийн нийт орны 23.2 хувь нь сумын ба сум дундын эмнэлэгт ногдож 2005 онтой харьцуулахад сумын ба сум дундын эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчийн тоо 6.8 хувиар буурсан бол эмнэлэгт үзүүлж тусламж, үйлчилгээ авсан хүний тоо 2.7 хувиар өссөн байна. Эрүүл мэндийн нэн шаардлагатай болон нэмэлт тусламж, үйлчилгээний багц, тэдгээрийн санхүүжилтийн зохицуулалт, өдрийн эмчилгээ үзүүлэх журмыг шинэчлэн боловсруулсан байна. Сумын эмнэлгийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд аймгийн төвөөс алслагдсан сумдын эмнэлэгт хурдавчилсан сорилын оношлуур, шинжлэгдэхүүнийг халдваргүйжүүлэх, сорьц авах өрөөг ариутгуураар хангаж байна.

**210.** Одоогоор нийслэлийн хороо, аймгийн сумын түвшинд үзүүлэх эмнэлгийн анхан шатны үйлчилгээ хүүхдэд хэрхэн нөлөөлж байгаа, түүнээс шалтгаалсан хүндрэл бэрхшээлийн талаар явуулсан тодорхой судалгаа, дүгнэлт байхгүй байна.

**211.** Монгол Улсын бүх аймгийн нэгдсэн эмнэлэгт нийт 892 их эмч, 1650 сувилагч, 2325 эмнэлгийн дунд мэргэжилтэн ажиллаж байна. Эмнэлгийн нийт орны тавны нэг нь хоёрдогч шатлалын эмнэлэгт ногдож, эмнэлгийн дундаж ор хоног 2005 онд 9.3 хувь байсан бол 2006 онд 8.9 болж буурсан байна. Сүүлийн гурван жилд дунджаар хоёрдогч шатлалын эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн 28.8 хувийг сумын эмнэлгээс дээд шатлалын эмнэлэгт шилжүүлсэн өвчтөн эзэлж, 2006 оныг 2005 онтой харьцуулахад 4 хувиар нэмэгдсэн байна.

**212.** Дорнод аймагт зүүн бүсийн, Өвөрхангай аймагт хангайн бүсийн, Ховд аймагт баруун бүсийн оношлогоо, эмчилгээний төв ажиллаж байна. Түүнчлэн Улаанбаатар хотод гуравдагч шатлалын 15 эмнэлэг үйл ажиллагаа явуулж байна. Улсын хэмжээнд 780 хувийн эмнэлэг ажиллаж байна. Өнгөрсөн 2006 оны байдлаар бүсүүдийн оношлогоо, эмчилгээний төвд 195 их эмч, 359 сувилагч, 522 эмнэлгийн дунд мэргэжилтэн ажиллаж байна. Харин гуравдагч шатлалын клиник, төрөлжсөн нарийн мэргэжлийн төвүүдэд 1147 их эмч, 1673 сувилагч, 2218 эмнэлгийн дунд мэргэжилтэн ажиллаж байна. Сүүлийн гурван жилд нийт хэвтэн эмчлүүлэгчийн 25 хувийг хөдөөгөөс шилжин ирсэн үйлчлүүлэгчид эзэлж байна. Дундаж ор хоног 2005 онд 12.2 байсан бол 2006 онд 10.9 болж буурсан байна.

**213.** Эрүүл мэндийн салбарын ерөнхий төлөвлөгөөг (2005–2015) хэрэгжүүлэх үүрэг бүхий зохицуулах албыг шинэчлэн байгууллаа. “Үр дүнд суурилсан удирдлага, төлөвлөлтийг эрүүл мэндийг салбарт турших аргачлал”-ын дагуу нийслэл, аймгийн эмнэлгийн удирдлага, нягтлан бодогч, орон нутгийн засаг захиргааны байгууллагын удирдах ажилтан нарт сургалт зохион байгуулан туршилтын эмнэлгүүдийн тусламж, үйлчилгээний нэгжийн өртгийг шинэ аргачлалаар тооцож эхэллээ. Энэ аргачлал нь эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах нэг чухал хүчин зүйл болно гэж үзэж байна. Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн тогтолцооны стратегийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд эмнэлэг дундын нэгдсэн сүлжээ байгуулах, бүртгэл мэдээлэл, статистикийн ажилтан нарын чадавхийг хөгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

**214.** Эрүүл мэндийн салбарын статистикийн зарим үзүүлэлт түүвэр судалгааны үзүүлэлттэй харьцуулахад зөрөөтэй байна.

**215.** Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн хэмжээ 2004 онд 77.6 тэрбум төгрөг, 2005 онд 83.7 тэрбум төгрөг, 2006 онд 103.1 тэрбум төгрөг болсноор 2006 оны байдлаар нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал 40 мянган төгрөгт хүрлээ. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн эх үүсвэрийн 70 орчим хувийг улсын төсөв, 20 гаруй хувийг эрүүл мэндийн даатгалын сан, үлдсэн 10 орчим хувийг эмнэлгийн төлбөрт үйлчилгээ, бусад орлого эзэлж байна. Эрүүл мэндийн урсгал зардлын 29.4 хувийг анхан шатны тусламж, үйлчилгээнд; 42.5 хувийг хоёрдогч шатлалын тусламж, үйлчилгээнд; 28.1 хувийг гуравдагч шатлалын тусламж, үйлчилгээнд тус тус зарцуулсан байна. Эрүүл мэндийн нийт зардлын 3.4 хувийг хөрөнгө оруулалт эзэлж байна.

**216.** Эмийн чанар, аюулгүй байдлыг хангах, хуурамч эм, эмийн зар сурталчилгаанд тавих хяналтыг сайжруулах чиглэлээр Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд зарим нэмэлт, өөрчлөлт орууллаа. Эрүүл мэндийн яам нийслэлд борлуулж байгаа эмийн нэр, олон улсын нэршил, үйлдвэрлэгч нь Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн эсэх, эмийн үнийн нэгдсэн мэдээллийг цахим хуудсаар дамжуулан сурталчилж байна.

“Иргэдэд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх нь”, “Эмнэлгийн эмийн хэрэглээг сайжруулах нь”, “Эмийн чанарыг сайжруулж, хуурамч эмтэй тэмцэхэд эм хангамжийн байгууллагын оролцоо” зэрэг сэдвээр сургалт зохион байгуулж, түүнтэй холбогдсон танилцуулга, сурталчилгааны материалыг бэлтгэн хэвлүүлж түгээсэн байна. “Эмийн үйлдвэрлэлд тавигдах ерөнхий шаардлага”, “Эмийн сангийн бүтэц, үйл ажиллагаа” зэрэг стандартыг боловсруулан гаргасан байна.

**217.** Япон Улсын Засгийн газрын санхүүгийн дэмжлэгээр 2005–2006 онуудад баруун болон зүүн бүсийн 4 аймгийн алслагдсан 64 суманд эмийн эргэлтийн сан шинээр байгуулснаар манай улсын 327 сумын 286 нь эмийн эргэлтийн сантай болж нэн шаардлагатай эмээр хангагдах боллоо. Эмийн эргэлтийн сан нь алслагдсан нутгийн хүн ам, эмзэг бүлгийн эх, хүүхдэд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад үнэлж баршгүй ашиг тус өгч байна.

**218.** Засгийн газар хүн амын цэвэр, аюулгүй ундны усны хүртээмж, ариун цэврийн байдлыг сайжруулах чиглэлээр олон улсын байгууллагатай хамтран ажиллаж байна. Мянганы хөгжлийн зорилтыг хангах хүрээнд хүн амыг ундны усны найдвартай эх үүсвэрээр хангах өртөг зардлыг тооцон усны нөөцийг зохистой ашиглах, усжуулалтын орчин үеийн арга ашиглах зорилтыг хэрэгжүүлж байна.

Улаанбаатар хот, Сэлэнгэ, Говьсүмбэр, Завхан, Говь–алтай, Увс аймгийн төвийн цэвэр, бохир усны байгууламжийг шинэчлэх, сайжруулах, улмаар төвийн болон зүүн бүсийн нийт найман аймагт шаардлагатай тоног төхөөрөмжийг суурилуулах ажлыг зохион байгуулав.

Нийтдээ 140 гаруй суманд ус зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх төхөөрөмж суурилуулан ажиллуулж байна. Мөн 17 аймгийн 117 суманд ус зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх төхөөрөмж шинээр суурилуулах зураг төсөл хийлгэж, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлсэн байна. ДЭМБ, НҮБ–ын Хүүхдийн сан, НҮБ–ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгээр сумын сургууль, эмнэлгийн ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжийг барьж байгуулж байна.

**219.** Тайлант хугацаанд хүн амын цэвэр, аюулгүй ундны усны хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хөрөнгө оруулалтад улсын төсвийн болон зээл, тусламжийн хөрөнгийн эх үүсвэрээс 5.0 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

**220.** Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн “Эрүүл мэдээлэл, сургалт, сурталчилгааны төлөвлөгөө” боловсруулан түүний дагуу эрүүл байх, зөв аж төрөх ёс зэрэг тусгай бэлтгэсэн сэдвээр лекц, сургалт зохион байгуулж, эрүүл мэндийн ухуулга, сурталчилгааг өргөжүүлж байна. Мөн “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага шалгаруулах журам”-ыг шинэчилж мөрдүүллээ. Хүүхдийн эрүүл өсч бойжих, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах чиглэлээр эмнэлгийн дунд мэргэжилтнийг сургалтанд хамруулах шаардлагатай байна

#### **А. Эх, хүүхдийн эрүүл мэнд, эрүүл мэндийн үйлчилгээ**

*(24 дүгээр зүйл)*

**221.** Монгол Улсын Засгийн газар өмнө дурдсан хөтөлбөрүүдээс гадна “Эхийн эндэгдлийг бууруулах” стратеги зэрэг бодлогын баримт бичгийг эх, нялхсын эрүүл мэндийг хамгаалахын чиглэлээр боловсруулан хэрэгжүүлж байна. Мөн “Эхийн амрах байр ажиллуулах журам”, “Эхийн амрах байрны үйл ажиллагаа, санхүүжилт”-ийн журмыг батлан сум, аймгийн эхчүүдийн амрах байрын хүчин чадлын жишгийг тогтоож өгсөн байна. Олон улсын байгууллагын дэмжлэгээр “Нярайн зайлшгүй шаардлагатай тусламж”, “Нярайн сэхээн амьдруулалт” зэрэг хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, түүнд сумдын эрүүл мэндийн ажилтныг хамруулж байна.

**222.** Гэр бүл төлөвлөлт, жирэмсний эрт үеийн хяналт, эрсдэлтэй болон жирэмсний хүндрэлтэй эхчүүдийг дээд шатлалын эмнэлэгт шилжүүлэх, хэвийн жирэмсэн болон төрсний дараа эх, нярайн эрүүл мэндийг хянах, бага насны хүүхдийн өсөлт хөгжлийг дэмжих, вакцинжуулах зэрэг үйл ажиллагааг өрхийн эмчийн хяналтын дор явуулж байна. Улсын хэмжээнд 2006 оны байдлаар эхийн амрах 335 байр байгаагийн 312 нь сумын төвд, 21 нь аймгийн төвд, 2 нь нийслэлд ажиллаж байна.

**223.** Монгол Улсад хүүхдийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх үйлчилгээний зардлыг төр хариуцдаг боловч анхан шатны тусламжийн хүрээнд 5 хүртэл насны хүүхдийн хэрэглэх эмийг эцэг, эхчүүд өөрсдөө худалдан авдгаас үүдэн хүүхдээ эмнэлэгт хэвтүүлэн эмчлүүлэхийг илүүд үзэх байдал давамгайлж байна.

**224.** Алслагдсан газар нутагт амьдардаг жирэмсэн эх орон нутгийн эхчүүдийн амрах байранд ирж төрдөг байдал сүүлийн гурван жилд өсөн нэмэгдсэн байна. Өнгөрсөн 2006 онд 47361 эх төрсний 8576 нь сум, сум дундын эмнэлэгт, 260 нь гэртээ, үлдсэн 38525 буюу 81.3 хувь нь аймгийн төв, нийслэлийн эмнэлэгт төрсөн байна. Харин гэрийн 260 төрөлтийн 56.9 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна. Нийт төрөлтийн 87.6 хувийг мэргэжлийн эх баригч, эмч удирдан явуулсан байна. Эндсэн эхчүүдийн 33.3 хувь нь жирэмсний үеийн хүндрэл, 21.2 хувь нь төрөх үеийн хүндрэл, 15.2 хувь нь төрсний дараах хүндрэл, үлдсэн 30.3 хувь нь жирэмсний болон төрөхөөс бусад төрлийн өвчнөөр нас баржээ. Эндсэн эхчүүдийн 6.1 хувь нь 20-иос доош насны эх байна. Мөн өсвөр насны охидын төрөлт 8–9 хувьтай байна. Төв, суурин газрын эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламж авах шаардлагатай гэж тогтоогдсон жирэмсэн эх орон нутгаас ирэх замын

зардалгүйгээс амь насаа алдах явдал гарсан байна.

**225.** Мянган амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 2000–2005 онд 36 хувиар буурсан байна.

**226.** Хүүхдийн өвчний цогц менежментийн болон бага насны хүүхдийн хөгжлийн цогц бодлогыг боловсруулан хэрэгжүүлж байна. Хүүхдийн өвчний цогц менежментийг 2000 оноос туршиж, 2006 оноос үндэсний хэмжээнд хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд нийслэлд шилжин ирсэн бүртгэлгүй болон орлого багатай өрхийн 500 орчим эцэг, эхэд хүүхэд асран хамгаалах мэдлэг, хандлагыг дээшлүүлэх сургалт зохион байгуулсан байна.

**227.** Тав хүртэл насны хүүхдийн эндэгдлийн шалтгаанд амьсгалын замын өвчин, нярайн эндэгдэл, осол гэмтэл тэргүүлэх байрыг эзлэх боллоо. Хүүхдийн халдварт өвчлөлийн дотор гахайн хавдар, сүрьеэ, салхин цэцэг, улаанууд зэрэг өвчин зонхилж байна. Вируст гепатит А, цусан суулга, хүнсний гаралтай бактерт хордлого, сальмонеллезийн халдвар, суулгат халдвар зэрэг гэдэсний халдварт өвчин нийт халдварт өвчний 21.5 хувийг эзэлж байна.

**228.** Монгол Улсын Засгийн газраас баталсан үндэсний товллын дагуу заавал дархлаажуулалтыг хэрэгжүүлж байна. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын иргэн, тус улсад байнга буюу түр оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг дархлаажуулалтад хамруулж байна. Дархлаажуулалтын тухай хуульд сүрьеэ, халдварт саа (полиомиелит), В вируст гепатит, сахаруу, хөхүүл ханиад, татран, улаан бурхны эсрэг сэргийлэх тарилгыг заавал дархлаажуулалтад оруулахаар заасан байна.

**229.** Тавт вакцин буюу хавсарсан вакциныг нийт 11 аймагт нэвтрүүлсэн байна.

**230.** Монгол Улсад дархлаажуулалтын өргөжүүлсэн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж, 2006 оны байдлаар нэг хүртэлх насны хүүхдээс сүрьеэгийн эсрэг (БЦЖ) вакцинд 98.2 хувь, халдварт саагийн вакцинд 98.3 хувь, саа, хөхүүл ханиад, татрангийн эсрэг вакцинд 99 хувь нь хамрагдаж дархлаажсан байна.

**231.** Халдварт өвчнийг эсэргүүцэх эм тарилга, вакциныг жил бүр 20 хувийн нөөцтэй байхаар тооцон заавал дархлаажуулалтад шаардагдах хөрөнгийг улсын төсвөөс санхүүжүүлж байна. Дархлаажуулалтын сангийн төсөв 2006 онд 481 сая төгрөгт, 2007 онд 661 сая төгрөгт хүрсэн байна.

**232.** Монгол Улсын Засгийн газар “Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл”, “Эх, хүүхдийг амин дэм, бичил тэжээлийн дутлаас сэргийлэх үндэсний стратеги–2005”, “Бага насны хүүхдийг төмрийн дутлын цус багадалтаас сэргийлэх” зэрэг хүүхдийн хоол, тэжээлийн хангамж, чанартай холбоотой хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна. Цэцэрлэгийн хүүхдийн болон сургуулийн сурагчдын үдийн цай, дотуур байрны хүүхдийн хоол, хүнсний норм, стандартыг шинэчлэх, шаардлагатай зардлыг нэмэгдүүлэх, түүнд олон нийтийн хяналтыг сайжруулах үйл ажиллагааг идэвхжүүлж байна. Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын хамтарсан тушаалаар Хүүхдийн цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн (0–18 насны) хоногийн хоолны илчлэг, нормативыг 2005 онд, Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах журмыг 2006 онд батлан хэрэгжүүлж байна.

**233.** Монгол Улсад 2005 оны судалгаагаар 5 хүртэлх насны хүүхдийн 6.3 хувь нь



тураалтай, 20.9 хувь нь өсөлтийн хоцролттой, 2.2 хувь нь туранхай байв. Энэ үр дүнг 2000 онд явагдсан судалгаатай харьцуулбал тураалтай болон туранхай хүүхдийн тоо 50 орчим хувиар, өсөлтийн хоцролттой хүүхдийн тоо 15 хувиар буурсан байна (MICS 2005).

Өнгөрсөн таван жилийн хугацаанд 5 хүртэлх настай хүүхдийн тураалын түвшин 2000 оноос даруй 6.4 нэгжээр (2000 онд 12.7 хувь, 2005 онд 6.3 хувь) буурсан хэдий ч бүсүүдийн хооронд нэлээд ялгаа байна. Тураалтай хүүхдийн хувийн жин баруун бүсэд 8 хувь, төвийн бүсэд 5 хувь байна. Тураалтай хүүхдийн зөвхөн 1.1 хувь нь хүнд хэлбэрийн тураалтай байна. Тав хүртэлх насны зөвхөн нэг хүүхэдтэй өрхийг тав хүртэлх насны 3 хүүхэдтэй өрхөд амьдарч байгаа хүүхэдтэй харьцуулахад тураалтай хүүхдийн хувь 2.6 орчим нэгжээр, өсөлтийн хоцролттой хүүхэд 20 орчим нэгжээр өндөр байна.

Хоол, тэжээлийн дутал охид, хөвгүүдийн хооронд маш бага ялгаатай байна. Охид тураал болон туранхайд өртөх нь илүү байхад хөвгүүд өсөлтийн хоцролтод өртөх нь илүү байна. Ялангуяа баруун бүсэд хүүхдийн хоол, тэжээлийн дутлын түвшин илүү өндөр байна. Үүнд нэг айлд 5 хүртэлх насны хүүхдийн тоо олон байх, хүүхдийн асран хамгаалагчийн боловсрол хангалтгүй байх зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байна. Өрхийн 5 хүртэлх насны хүүхдийн тоо улсын дунджаар  $1.36 \pm 0.6$  байхад Баян-Өлгий аймагт  $1.81 \pm 1.02$  байна. Хүүхдийн амьдралын эхний 4 сар хүртэл эхийн сүүгээр дагнан хооллож буй үзүүлэлт 79.7 хувь байсан бол 6 сартай болоход 38.3 хувь болтлоо буурч байгааг эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний импорт, худалдан авалт нэмэгдэж, эрт нэмэгдэл хоолонд оруулах хандлага байгаатай холбон үзэж байна.

Харин хүүхдийн анхны нэмэгдэл хоолны нэр төрөл өмнөх судалгаатай харьцуулахад олширсон хэдий ч 6–59 сартай хүүхдийн идэж буй хоол хүнсний бүтцэд гурил, мах, будаа, сүүн бүтээгдэхүүн давамгайлсан хэвээр байна.

**234.** Бага насны хүүхдийн хоол тэжээлийн байдалд гарсан нааштай хандлага, өөрчлөлтийг 2000 оноос хойш хэрэгжүүлсэн хэд хэдэн үйл ажиллагаатай холбон тайлбарлаж болно. *Тухайлбал*, 2000 оноос хойш Засгийн газраас боловсруулан хэрэгжүүлсэн бодлого, үндэсний хөтөлбөрүүдэд хүн амын, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийн хоол, тэжээлийн байдлыг сайжруулах талаар дэлгэрэнгүй тусгаж, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлж байна. Мөн 2000 оноос 2 хүртэлх насны хүүхдийг өсөлтийн хяналтад сар бүр хамруулж, улмаар 2000–2001 онд болсон зудын гамшгийн үеэр хоол тэжээлийн дуталд өртөж болзошгүй хүүхдэд өндөр илчлэгтэй ВР–5 тэжээл, “Палли” жигнэмэгийг бүх аймагт (366914.4 кг) түгээсэн байна.

**235.** Үндэсний түвшинд 6–59 сартай хүүхдийн 41.0 хувь нь Д амин дэмийн нөөц багатай байгаа хэдий ч бүс нутгуудад болон насны бүлэгт жигд тархалттай байна. Рахитын үлдэцийн нэг ба түүнээс дээш шинж тэмдэг 2 хүртэлх насны хүүхдийн 41.5 хувьд илэрч байхад хоёр ба түүнээс дээш шинж тэмдэг 20.8 хувьд илэрсэн юм. Үндэсний түвшинд 6–59 сартай хүүхдийн 51.6 хувь нь А амин дэмийн түгээлтэд хамрагдаж байна. Энэ үзүүлэлт Улаанбаатар хотод 52.3 хувь байна.

Хүүхдийн А амин дэмжүүлэлтийн хамралт бүс нутаг болон насны бүлэгт жигд 48–53 хувь байна. А амин дэмжүүлэх үйл ажиллагааны талаар эцэг, эх, асран хамгаалагч нар хүүхдийн уусан А амин дэмийн тоо, тун, уух шаардлага, хэрэгцээний талаар төдийлэн сайн мэдээлэлгүй байдаг байна. Үндэсний түвшинд 8–12 насны хүүхдийн дунд бамбайн

бахлуурын тархалт 13.8 хувь байна. Таван жилийн өмнөх дүнгээс 7.6 хувиар буурч Монгол Улс иод дутлын хөнгөн зэрэгтэй гэсэн ангилалд шилжсэн байна.

**236.** Ураг, жирэмсний ба төрөх үе, нярай, нялхсыг асран хамгаалах үйл ажиллагааг эрчимжүүлэх, ялангуяа хөдөөгийн болон хот, суурин газрын гэр хороололд эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах шаардлагатай байна. Хөдөөгийн эмнэлгүүдийн хязгаарагдмал нөөцийн дутагдлыг арилгах, эм хангамжийг сайжруулах, эмнэлгийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, эмнэлгийн шаталсан тогтолцоог боловсронгуй болгох явдал чухал байна.

### **Б. Өсвөр үеийн эрүүл мэнд**

**237.** Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай (ХДХВ/ДОХ) хуулийг 2004 онд шинэчлэн батлуулж, хүний эрхийг хамгаалах, ялангуяа хувь хүний нууцыг хүндэтгэх заалтыг шинээр нэмж оруулсны зэрэгцээ албадлагын шинжтэй зүйлийг хассан байна.

**238.** Монгол Улс “Гурван нэг” зарчмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ХДХВ-той тэмцэх 2002–2010 оны үндэсний стратегийг 2003 онд боловсруулсан билээ. ДОХ-той тэмцэх үндэсний зөвлөлийг 2006 оноос шинэчлэн Монгол Улсын Шадар сайд удирдах болсон бөгөөд ДОХ-той тэмцэх үндэсний хөтөлбөрийн хяналт– шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тодорхойллоо.

**239.** ХДХВ-ын халдварын анхны тохиолдол бүртгэснээс хойш 2006 оны эцэс хүртэл нийт 25 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд түүний 20 нь 2005–2006 онд илрээд байна. ХДХВ-ийн халдвар авсан 17 эрэгтэй хүний 12 нь ижил хүйстний бэлгийн хавьтлаар авсан байна<sup>6</sup>. ДОХ- оор өвчилсөн нэг хүний эмчилгээний шууд зардал жилд 3.6–гаас 10.2 сая төгрөгт хүрч байна.

**240.** Монгол Улсын хэмжээнд 2006 оны байдлаар бэлгийн замаар дамжих халдварын 12787 тохиолдол бүртгэгдсэний дотор трихомониаз, заг хүйтэн, тэмбүү өвчин зонхилж, төрөлхийн тэмбүүгийн 51 тохиолдол илэрсэн байна. Бэлгийн замаар дамжих халдварын тархалт нэмэгдэн архидалт, гэр бүлийн хүчирхийлэл буурахгүй байна. Ялангуяа эрхэлсэн ажилгүй, тэнэмэл, орон гэргүй, төлбөрийн чадваргүй хүмүүсийн дотор бэлгийн замын өвчин өндөр байна.

**241.** Бэлгийн замын халдварт өвчин, ХДХВ/ДОХ-ын тархалтыг бууруулахад бэлгэвчийн хэрэглээг нэмэгдүүлэх явдал чухал үүрэгтэй бөгөөд Эрүүл мэндийн яамны статистикийн мэдээллээр сүүлийн жилүүдэд бэлгэвчийн хэрэглээ нэмэгдэж байна.

**242.** Өсвөр үеийнхний эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн ээлтэй тусламж, үйлчилгээний загварыг боловсруулан сонгосон аймаг, дүүрэгт өсвөр үеийнхний эрүүл мэндийн кабинет, “Ирээдүйн босго” төвийг байгуулан ажиллуулж байна. Эрүүл мэндийн боловсролын стандартад нийцүүлэн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан “Эрүүл мэндийн боловсрол” сурах бичиг боловсрууллаа.

**243.** Сүүлийн 5 жилд сүрьеэгээр нас барах тохиолдол буурсан ч шинээр өвчлөгчдийн тархалтын түвшин 2000–2006 онд 125–185.3 болтлоо нэмэгдсэн байна. Сүрьеэгийн

<sup>6</sup> Мянганы хөгжлийн зорилтын хоёр дахь тайлан, 2007, хуудас 48

өвчлөл төвийн болон зүүн бүсэд өндөр байна. Өвчлөгчдийн 70 орчим хувийг 16–44 насны хүмүүс эзэлж байна. Сүрьеэтэй тэмцэх үйл ажиллагааг хүн амын ядуурлыг бууруулах, орон сууцны болон орчны эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах ажилтай уялдуулах явдал чухал байна. Нийгмийн эмзэг бүлгийнхний дотор өвчний тархалтыг эрт илрүүлэх, бүрэн эмчлэх ажлыг зохион байгуулах тогтолцоог боловсронгуй болгох хэрэгтэй байна.

**244.** Тамхины хяналтын тухай хуулийг 2005 онд шинэчлэн баталсан бөгөөд энэхүү хуулиар тамхины хэрэглээ, дам тамхидалтаас үүдэлтэй сөрөг үр дагавраас хүн амыг хамгаалах зорилго бүхий тамхины хяналтын эрх зүйн үндсийг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулсан байна. Тамхины хяналтын тухай хуулиар 18 нас хүрээгүй хүнд тамхи худалдах, түүгээр тамхи худалдуулах, түүнчлэн олон нийтийн газар, аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөгдсөн газраас бусад газар тамхи татахыг хориглосноос гадна хүүхдэд тамхи татахыг сургасан, өөгшүүлсэн зар сурталчилгааг хориглосон байна.

Иргэдэд эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх, тамхины хэрэглээг бууруулах зорилгоор эрүүл мэндийг дэмжих санг тамхины онцгой албан татварын 2 хувьтай тэнцэх хөрөнгөөр байгуулахаар заасан юм. Энэ сангийн хөрөнгийг тамхины хяналт, эрүүл мэндийг дэмжих төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, тамхинаас үүдэлтэй өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх, тамхины хор хөнөөлтэй тэмцэх талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах, хяналт тавих, тамхинаас гаргах эмчилгээ, түүнд шаардлагатай эм, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх, тамхины хэрэглээ, түүний эрүүл мэндийн болон эдийн засгийн хор холбогдлыг судлахад зарцуулахаар хуульчилсан байна.

Өсвөр үеийнхний эрүүл мэндийн зан үйл, дадал, хандлагын талаарх 1997 оны судалгааны тайлангаас үзэхэд судалгаанд хамрагдсан 2040 хүүхдийн 16.4 хувь (334) нь тамхи татдаг, гэхдээ тэдний 65.6 хувь нь тамхиа хаяхыг хүсч байна<sup>7</sup>. Тамхи татдаг хүүхдийн 78.7 хувийнх нь ар гэрт тамхи татдаг хүн байдаг төдийгүй Улаанбаатар хотод хүүхдэд илүү эрт тамхи татаж эхэлж байна. Дунд сургуулийн ахлах ангийн тамхи татдаг сурагчдын 40 хувь нь 12–13 насандаа, 34.4 хувь нь 14–15 насандаа анх тамхи татжээ.

Монгол дахь архидалтыг үнэлэх 1998 оны судалгаагаар хүн амын 51.2 хувь нь архи тогтмол хэрэглэдэг болох нь тогтоогджээ. Хорь хүртэлх насны өсвөр үеийнхний 71 хувь нь, 16 хүртэлх насныхны 54.7 хувь нь архи хэрэглэж үзжээ. Ажилгүйдэл, ядуурал нэмэгдэж, баян хоосны ялгаа ихсэж, хүн амын аж амьдрал ерөнхийдөө доройтож байгаа явдал архидалтын нэг шалтгаан болж байна. Өсвөр үеийнхний хэрэгцээг тодорхойлох судалгаагаар (2000) хот, хөдөөд ялгаагүй дунджаар 17.6 наснаас эхлэн согтууруулах ундааг хэрэглэж эхэлдэг төдийгүй согтууруулах ундааг хотод амьдардаг өсвөр үеийнхэн хөдөөнийхнөөс 2 дахин илүү хэрэглэж байна.

<sup>7</sup> Өсвөр үеийн эрүүл мэнд, хөгжил судалгаа, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, 2003

### **Хүүхдийн хамгааллын үйлчилгээ**

*(26, 27 дугаар зүйл)*

**245.** Нийгмийн халамжийн тухай хуулийг 2005 онд шинэчилж, ядуу болон нэн ядуу амьдралтай өрхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эмэгтэйчүүд, хүнд нөхцөлд байгаа хүүхдүүд, ганц бие өрх толгойлсон ядуу иргэд, хүчирхийлэлд өртсөн иргэд нийгмийн халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдахаар болсон байна.

**246.** Нийгмийн халамжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “нөхцөлт мөнгөн тэтгэмж, нийгмийн халамжийн тусламж, хөнгөлөлт, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах өрх, иргэнийг тодорхойлох үүрэг бүхий Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөл сум, хороонд ажиллана” гэж заасан байна.

Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж, нэн ядуу иргэнд орон сууцны хөлс төлөх, түлээ, нүүрс худалдан авахад зориулан жилд нэг удаа олгох мөнгөн тусламж, халамжийн цэцэрлэгийн үнийн хөнгөлөлт, протез, ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн хангамж, сэргээн засах үйлчилгээний зардлын хөнгөлөлт, эх орны рашаан сувиллын зардлын хөнгөлөлт зэрэг хөнгөлөлт, тусламж, мөн амьдралын итгэл үнэмшил, хөдөлмөрийн дадал олгох, авъяасыг дэмжих зорилгоор зөвлөлгөө өгөх, сургалт зохион байгуулах, зохион байгуулалттайгаар хөдөлмөр эрхлүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох зэргээр ядуурлаас гарахад нь туслах, энэ чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт зуучлах, сэргээн засах үйлчилгээнд хамруулах үйлчилгээг үзүүлнэ.

**247.** Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлд хүүхдэд нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авах бөгөөд хүүхдийг асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэх журам, асрамжийн байгууллагын жишиг дүрмийг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар заасан юм. Үүний дагуу Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 3 дугаар сарын 7–ны өдрийн 29 дүгээр тушаалаар Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын мөрдөх үлгэрчилсэн дүрмийг баталсан байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд төрөлжсөн асрамжийн үйлчилгээ нь асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, байнгын эмчилгээ, асаргаа шаардагдах хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүнчлэн хүнд нөхцөлд байгаа хүүхдийг байршуулан хоол, хувцас, эмнэлэг, соёл, ахуй, сэтгэл зүй, асаргаа сувилахуйн үйлчилгээ үзүүлэх, тэдний хэвийн амьдралын нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсны эрх ашгийг хамгаалах үйл ажиллагааг явуулах, 30 дугаар зүйлд төрөлжсөн асрамж, үйлчилгээний зардлын норм норматив, эд хөрөнгийн эдэлгээний хугацааны болон үйлчилгээ үзүүлэх журам, тогтоох болон төрөлжсөн асрамж, үйлчилгээний стандарттай байхаар заасан байна.

**248.** Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулиар хүүхдэд халамж, асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хүүхдийн нас, бие бялдар, сэтгэхүйн онцлогт тохирсон, эрүүл ахуйн стандарт, шаардлага хангасан, аюулгүй, хүчирхийлэлгүй орчин бүрдүүлэх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэг,

шинжилгээ, дархлаажуулалт болон эрүүл мэндийн даатгалд хамруулах, хүүхдийн өсөлт хөгжил, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн баталгаат хоол хүнс, хувцас, ахуйн хэрэгслээр хангах, хүүхдийг төлөвшүүлэх, хөгжүүлэх, боловсрол эзэмших боломж, нөхцөлийг бүрдүүлэх, хүүхдийг гэмт хэрэг, эрх зүйн зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хүүхдийг хамгаалах, үзэл бодлыг нь хүндэтгэх, ялгаварлан гадуурхахгүй байх үүргийг хүлээлгэсэн байна.

Мөн хүүхдэд үзүүлсэн нийгмийн халамжийн үйлчилгээний тайлан, хүүхдийн шилжилт хөдөлгөөний тухай мэдээллийг аймаг, нийслэлийн Засаг даргад өгч байх, хүүхдийг бусдын асрамжид хууль бусаар шилжүүлэхгүй байх үүргийг хүлээлгэсэн байна.

**249.** Улсын болон орон төсвөөс санхүүжүүлдэг хүүхдийн тодотголтой нийт 7 асрамжийн газар байгаагийн 5 нь Улаанбаатар хотод, 2 нь Дархан–Уул, Орхон аймагт ажиллаж байна. Байгууллага тус бүрээр үйл ажиллагааг тодотгон үзүүлбэл:

- Өнчин хүүхдийн асран хүмүүжүүлэх төв Улаанбаатар хотод байрладаг бөгөөд цэцэрлэг, дотуур байр гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Цэцэрлэгт 3–7 насны 120 хүүхэд, дотуур байранд 8–18 насны 140 хүүхэд хүмүүжиж байна.
- Нялхсын клиник сувилал 1991 онд Улаанбаатар хотод байгуулагдсан бөгөөд дутуу нярай төрсөн болон эцэг, эх нь хаясан, эзэнгүй орхигдсон нийт 100 орчим 0 – 3 насны хүүхдийг асарч байна.
- Нийслэлийн цагдаагийн газрын харьяа Хүүхдийн халамж, үйлчилгээний төв гудамж, орц, хонгилд байгаа, халамж хүссэн хүүхдийг 14 хүртэл хоног асрамжлан гэр бүлд нь шилжүүлэх үйл ажиллагааг явуулж байна.
- Хөдөлмөр, хүмүүжил сургалтын төв эцэг, эхийн хяналтаас гарсан 140 орчим хүүхдэд нийгмийн халамж, үйлчилгээг үзүүлж байна.
- Амьдрах ухаан сургалтын төв орон гэргүй 19–24 насны өсвөр үеийнхэн болон залуучуудад нийгмийн үйлчилгээг үзүүлж байна.

**250.** Эдгээр халамжийн байгууллагуудад нийт 500 орчим хүүхэд хүмүүждэг бөгөөд бүгд боловсролын зохих шатны үйлчилгээнд хамрагдаж байна. Эдгээр байгууллагад хүмүүжиж байгаа хүүхдийг 18 насанд хүрэхээр дээд сургууль, хөдөлмөрт хэрхэн шилжүүлдэг талаар Хүүхэд асран хүмүүжүүлэх төвөөс бусад газарт мэдээлэл байхгүй байна.

**251.** Хүүхдэд халамжийн үйлчилгээ үзүүлэхээр албан ёсоор зөвшөөрөлтэй дотоод, гадаадын 46 байгууллага үйл ажиллагаа явуулж 1500 гаруй хүүхдийг түр асран хүмүүжүүлж байна. Хүмүүжиж байгаа нийт хүүхдийн 20 хувь нь бүтэн өнчин, 50 хувь нь хагас өнчин, үлдсэн хувь нь эцэг, эхтэй хүүхдүүд байна. (Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны мэдээ 2006 он)

**252.** Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам болон холбогдох талууд хамтран халамж, асрамжийн байгууллагуудын үйл ажиллагаанд 2006, 2007 онд жил дараалан хяналт шалгалт явуулсан байна. Шалгалтын дүнд гадаадын иргэн, байгууллагын санхүүжилттэй төвүүд халамжийн үйлчилгээ явуулахдаа Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн “Хүүхдэд шашны үзэл номлолыг тулган хүлээлгэх, хүүхдийг хууран мэхлэх замаар шашны үйл ажиллагаанд татан оролцуулах, шашны сургууль, сүм хийдэд албадан суулгахыг хориглоно” гэсэн заалт болон мөн хүүхдэд үзүүлсэн нийгмийн халамжийн

үйлчилгээний тайлан, хүүхдийн шилжилт хөдөлгөөний тухай мэдээллийг аймаг, нийслэлийн Засаг даргад тогтмол тайлагнах журмыг зөрчсөөр байна гэж дүгнэлт гаргасан байна.

**253.** Асрамж, халамжийн төвд хүүхдийн бүртгэл, хөдөлгөөний талаарх мэдээлэл хяналтгүй байна. Энэ байгууллагуудад хүүхдийн эрх зөрчигдөхөөс хамгаалах хяналт-шилжилгээ, үнэлгээний журам байхгүй бөгөөд хэрвээ хүүхдийн эрх зөрчигдсэн нөхцөлд хамгаалах арга хэрэгсэл тодорхойгүй хэвээр байна.

**254.** Хүүхдийн асрамж, халамжийн байгууллага Улаанбаатар болон томоохон суурин газар төвлөрч байгаагаас үүдэн хөдөө орон нутаг болон алслагдсан хязгаар нутагт асрамж, халамж шаардлагатай хүүхдийг төв, суурин газрын асрамж, халамжийн газарт шилжүүлсээр байна. Хөдөөгийн хүүхдийг хот, суурин газар шилжүүлсний дараа хүүхдийн үндсэн засаг захиргаа хуулиар хүлээсэн үүргийн дагуу хяналт тавьж чадахгүй байна.

**255.** Нийгмийн халамжийн тухай хуулийн 26 дугаар зүйлд олон нийтийн оролцоонд түшиглэсэн эмзэг бүлгийн халамжийн үйлчилгээний төрлийг амьдралын итгэл үнэмшил, хөдөлмөрийн дадал олгох, авъяасыг дэмжих зорилгоор зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах; зохион байгуулалттай хөдөлмөр эрхлүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох зэргээр ядуурлаас гарахад туслах, энэ чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдэд зуучлан хамруулах; сэргээн засах үйлчилгээнд хамруулах; түр байрлуулан асрамжлах; гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулахаар заасан байна.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хөтөлбөр”-ийг 2006 онд батлан хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөр хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүнд нөхцөлд байгаа хүүхэд, хүчирхийлэлд өртсөн болон орон гэргүй, тэнэмэл амьдралтай иргэнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг хүргэх бүтцийг бий болгоход чиглэсэн байна. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хөтөлбөрийн хүрээнд хүнд нөхцөлд байгаа хүүхдийг түр болон байнга байрлуулан асрамжлах үйлчилгээ, гэр бүлд асруулах үйлчилгээ, өдрийн ба халамжийн цэцэрлэгт хамруулах үйлчилгээ үзүүлэхээр тусгасан байна.

Түүнчлэн хараа хяналтгүй хүүхдийг олон нийт, гэр бүлийн орчинд амьдрах аятай нөхцөлийг бүрдүүлэх, хүүхдийн эрхийг олон нийтэд сурталчлах үйл ажиллагааг явуулахаар тусгажээ. Гэвч нийгмийн халамжийн сангаас олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээнд зарцуулах төсөв хөрөнгийн хуваарилалт хангалтгүй, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх байгууллагыг ил тод, нээлттэй сонгон шалгаруулах байдал дутагдалтай байна.

**256.** Төвөөс алслагдсан айл өрх, иргэд, хүүхдэд хүргэх нийгмийн суурь үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, нийгэм, хамт олонд түшиглэсэн үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран “Нийгмийн цогц суурь үйлчилгээний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд өрхийг чадваржуулах хамгийн үр дүнтэй стратегийг боловсруулсан гэж үзэж байна. Өрх бүр өөрийн хөгжлийн байдалд үнэлгээ хийж, тулгамдсан асуудлаа шийдвэрлэх ямар арга зам байгааг сонгож түүнийгээ идэвхитэй хэрэгжүүлдэг юм. Энэ ажлын хүрээнд өрхийн гишүүд бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хувилбарт сургалт,

олон нийтэд түшиглэсэн усны хэрэглээ, эрүүл ахуйн үйлчилгээ, хүүхдийн зөв өсөлт хөгжлийг өөрсдөө хянах арга зүйд суралцах зэргээр өрх гэр бүлийн хөгжлийн зангилаа асуудлыг шийдвэрлэхэд оролцож, амьдралын идэвхитэй хэлбэрт шилжиж байна. Энэ ажлын явцад нийгэм, хамт олонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээний үр дүнтэй шинэ загварууд хөгжиж байна.

**257.** Монгол Улсын төрийн байгууллагын зүгээс үзүүлж буй хүүхэд хамгааллын үйлчилгээ өмнөх үеийн тогтолцооноос уламжлагдан ирсэн учраас нийгмийн өөрчлөлтийн үйл явц, нөхцөл байдалд тохирохгүй байна<sup>8</sup>. Эдүгээгийн нөхцөлд болон ирээдүйд үүсэж болзошгүй хүүхдийн эмзэг байдал, эрсдэл, сөрөг нөлөөллийг арилгах гарц олоход туслах чиглэлээр явуулсан судалгааны дүнгүүд хүүхэд хамгааллын тогтолцоог шинэчлэх нь зүйтэй гэдгийг нотолж байна.

### **Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд**

*(23 дугаар зүйл)*

**258.** Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн дүгнэлт, зөвлөмжийн 42 дугаар заалтыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Засгийн газар Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөр болон Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөрийг 2006 онд батлан хэрэгжүүлж байна. Эдгээр хөтөлбөрийг 2006–2012 оны хугацаанд хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийн эрх, эрх чөлөөг хангахад тулгарч байгаа хүндрэлтэй асуудлыг төрийн ба иргэний нийгмийн байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэхэд чиглэгдэж байна.

**259.** Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийн үзэл санааг одоогийн байдлаар 30 гаруй хууль тогтоомжид тусган мөрдөж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай, Нийгмийн халамжийн тухай, Боловсролын тухай зэрэг хуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хүндэтгэн хамгаалах заалтыг шинээр нэмж тусгасан байна. Тухайлбал, Боловсролын тухай хуульд иргэнийг сурч боловсроход хөгжлийн онцлог, эрүүл мэндээр нь ялгаварлан гадуурхахгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамран сургах нөхцөл бололцоог бүрдүүлэх үүргийг төр хүлээхээр хуульчилсан байна.

**260.** Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлд нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж; нийгмийн халамжийн тэтгэвэр; нөхцөлт мөнгөн тэтгэмж; тусламж, хөнгөлөлт; төрөлжсөн асрамжийн үйлчилгээ; олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ; хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ; эрүүл мэндийн үйлчилгээ; боловсрол, соёл, урлагийн үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдах эрхтэй болохыг тодорхойлсон байна. Энэхүү хуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд нийгмийн халамжийн сангаас дараахь тусламж, хөнгөлөлтийг үзүүлэхээр заасан байна. Тухайлбал,

Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй, нэн ядуу амьдралтай өрхөд орон сууцны хөлс төлөх, түлээ нүүрс худалдан авахад нь жилд нэг

---

<sup>8</sup> Монгол Улс дахь хүүхэд хамгааллын тогтолцоо судалгааны тайлан, Их Британий Хүүхдийг ивээх сан 2006.

удаа олгох мөнгөн тусламж;

Арван найман нас хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоодод хийлгэсэн протезийн үнийг хоёр удаа зуун хувь нөхөн олгох;

Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн протезийн үнийг эхний удаа зуун хувь, хоёр дахь удаа тавин хувь нөхөн олгох;

Ядуу амьдралтай өрхийн 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүнчлэн нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсээгүй, ядуу амьдралтай өрхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийг нэг удаа нөхөн олгох;

Харах, сонсох, ярих боломж нь хязгаарлагдмал сурагч болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн тусгай сургуульд ирж, очих унааны зардлыг жилд нэг удаа хөнгөлөх;

Нэн ядуу амьдралтай өрхийн хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан иргэн дотоодын рашаан сувилалд сувилуулбал эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа нөхөн олгох;

Нэн ядуу амьдралтай өрхийн хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан иргэний 4 хүртэлх насны нэг хүүхдийн цэцэрлэгийн хоолны зардлын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх;

Ядуу амьдралтай, хөдөлмөрийн чадвартай гишүүнгүй, насанд хүрсэн бүрэн хараагүй иргэнтэй өрхийн суурин телефон утасны төлбөрт хөнгөлөлт үзүүлэх зэрэг болно.

Засгийн газраас хэрэгжүүлж байгаа Хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх, Осол гэмтлээс сэргийлэх, Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, Сохролоос урьдчилан сэргийлэх зэрэг олон тооны хөтөлбөр, төслүүд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндийг хамгаалахад нааштай үр нөлөө үзүүлж байна.

Эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлд сэтгэцийн эмгэгийн эмчилгээ, удаан хугацааны нөхөх эмчилгээ шаардах эмгэгийн болон хөнгөвчлөх эмчилгээний зарим зардлыг төрөөс хариуцаж байхаар заасан болно. Мөн Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэд зарим төрлийн эмийн үнийн хөнгөлөлт эдэлж байна.

Эрүүл мэндийн яам хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах үйлчилгээг нийгэм, хамт олонд түшиглэн явуулах бодлогыг баримтлаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд цахилгаан, хөдөлгөөн, рашаан, агаар, нар, усан, шавар эмчилгээ болон иллэг бариа, зүү төөнүүр зэрэг сэргээн засах эмчилгээг үзүүлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийн сэргээн засах үйлчилгээг Улаанбаатар хот, аймгийн төвийн клиникийн ба нэгдсэн эмнэлгүүд амбулаториор үзүүлэх бололцоотой хэдий ч хөдөө орон нутагт энэ үйлчилгээ хязгаарлагдмал байна.

**261.** Хөгжлийн бэрхшээлтэй иргэний талаарх хуулийн тодорхойлолт хэт ерөнхий байна<sup>9</sup> гэж Хүний эрхийн Үндэсний Комисс үзсэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлд “төрөлхийн болон удамшлын эмгэг өөрчлөлт, эсхүл осол, гэмтлийн улмаас сэтгэц, оюун ухаан, мэдрэхүйн чадавх нь алдагдсан, түүнчлэн

<sup>9</sup> Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын тухай илтгэл, 2007. (ХЭҮК) хуудас 20–58



бие эрхтэн нь гэмтсэнээс хөдөлмөрлөх, бие даан амьдрах боломж нь хязгаарлагдсан хүнийг “хөгжлийн бэрхшээлтэй иргэн” гэж ойлгоно” хэмээн томъёолсон байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд “бүрэн хараагүй, хэлгүй, дүлий, одой иргэн, эдгээрээс бусад хөдөлмөрийн чадвараа 70 ба түүнээс дээш хувиар алдсан, бие даан амьдрах чадваргүй хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийгмийн халамжийн тэтгэвэр авах эрхтэй” гэдгийг заасан байна. Гэтэл Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1997 оны А/250 дугаар тушаалаар батлагдсан “Ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчин, гэмтлийн жагсаалт”-д хөнгөн хэлбэрийн оюуны хомсдолтой, уналтын улмаас мэргэжлийн ажлаа хийх боломжгүй, нэг нүд сохор, хоёр хөл болон хоёр шуу, шилбэний тайралттай зэрэг хүмүүсийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг 70-аас доош хувиар тогтоосон байна. Өөр хоорондоо зөрчилтэй хууль тогтоомжийн заалт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мөнгөн тусламж авах эрхийг хязгаарлахад хүргэж байна гэж Хүний эрхийн Үндэсний Комисс дүгнэсэн байна.

**262.** Хөгжлийн бэрхшээлийг магадлах комисст хүүхдийн эмчийг ажиллуулах, хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, онцлогт нийцсэн үйлчилгээг хөгжүүлэх, ялангуяа хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх нийгмийн үйлчилгээний тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна.

**263.** Үндэсний статистикийн газар, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам хамтран Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхцөл байдлын зураглал судалгааг хийж, түүнд суурилсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх бодлогын зөвлөмжийг боловсруулсан байна. Үндэсний статистикийн газрын 2006 оны судалгаагаар 0–16 насны хөгжлийн бэрхшээлтэй нийт 6897 хүүхдийн 37 орчим хувь нь олдмол хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй байгаагийн дотор 75.6 хувь нь ердийн өвчнөөс, 18.9 хувь нь ахуйн ослоос, 2 хувь нь мэргэжлээс шалтгаалах өвчнөөс, үлдсэн 3.5 хувь нь үйлдвэрлэлийн ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

Монголчуудын уламжлалт амьдралын хэв маягтай холбоотой морь малаас унаж бэртэх зэргээс хөгжлийн бэрхшээлтэй болох тохиолдол хөдөө орон нутагт илүү гардаг байна. Улсын хэмжээнд 2006 онд явагдсан хурдан морины уралдаанд 10000 орчим хүүхэд морь унаж оролцсон бөгөөд тэдний 500 орчим нь уралдааны явцад бие эрхтэндээ гэмтэл авсан байна. Бэртэл гэмлийн зэргийн хувьд 39.8 хувь нь хөнгөн, 31 хувь нь хүндэвтэр, 20.8 хувь нь хүнд гэмтэл авчээ<sup>10</sup>.

Эхийн хэвлийд эрүүл бойжиж байсан хүүхэд төрөх үеийн болон төрөлтийг удирдах явцын алдаанаас үүдэн тархины саажилттай болох тохиолдол гарч байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй 6897 хүүхдийн 1080 нь харах эрхтний өөрчлөлттэй, 1517 нь сонсгол, хэл ярианы согогтой, 1663 нь хөдөлгөөний согогтой, 1457 нь оюун ухааны хомсдолтой, 596 нь сэтгэцийн эмгэгтэй, 676 нь хавсарсан согогтой байна. Хөгжлийн бэрхшээлтэй 0–16 насны хүүхдийн тоо 2004 онд 6025 байснаа 2006 онд 6897 (үүний 45.9 хувь нь эмэгтэй хүүхэд)–д хүрч 12.7 хувиар өссөн бөгөөд Улаанбаатар, Хөвсгөл, Завхан, Дорнод зэрэг газарт өсөлт илүү байна.

<sup>10</sup> Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын тухай илтгэл, 2007. ХЭҮК, хуудас 20–58

**264.** Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрх төдийлөн хангагдаж чадахгүй байгааг Хүний эрхийн Үндэсний Комиссын тайлан илтгэлд тэмдэглэсэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эхийн холбооноос 2006 онд явуулсан “Монгол дахь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн байдал” судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй 975 хүүхдээс хот, суурин газар амьдардаг хүүхдийн 70.5 хувь, хөдөө орон нутагт амьдардаг хүүхдийн 73.0 хувь сэргээн засалтын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байна. Мөн эдгээр хүүхдийн дөнгөж 20 хувь нь протез, ортопедийн хэрэгсэл ашиглаж байна. Нийгмийн халамжийн байгууллагаас нийлүүлж байгаа тэргэнцэр, сонсголын аппарат зэрэг хэрэгслийн чанар шаардлага хангахгүй байна.

**265.** Нийгмийн халамжийн сангаас үзүүлж байгаа тусламж, үйлчилгээг зөвхөн хөдөлмөрийн чадвараа алдсан, нэн ядуу амьдралтай иргэд хүртэх боломжтой байна. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ялгаварлан гадуурхах шалтгаан болдог байна<sup>11</sup>. Түүнчлэн зарим тусламж, үйлчилгээ амьдралаас хэт тасархай, хэрэгжүүлэх бололцоогүй байна. Тухайлбал, амьжиргааны түвшин тодорхойлох шалгуур үзүүлэлтийн дагуу дээд ба мэргэжлийн сургууль төгссөн буюу хувьдаа орон сууцтай бол тэр иргэнийг ядуу гэж үздэггүй, нэн ядуу амьдралтай өрхийн хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан иргэн дотоодын рашаан сувилалд сувилуулбал эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа хөнгөлдөг зэрэг амьдралд тохирохгүй зүйлийг дурдаж болно.

Иймд амьжиргааны түвшин тодорхойлох шалгуур үзүүлэлтийг амьдралд нийцүүлэн дахин хянаж үзэх нь зүйтэй байна.

**266.** Нөхөн сэргээх үйлчилгээний үр дүн тоног төхөөрөмж, аппарат хэрэгслийн хангамжтай шууд холбоотой билээ. Эрүүл мэндийн яамны судалгаагаар нөхөн сэргээх үйлчилгээний тоног төхөөрөмж хуучирсан, хүрэлцээгүйн улмаас хэт ачаалалтай ажилладгаас эмчилгээний чанарт сөргөөр нөлөөлж байна гэсэн дүгнэлт гарчээ.

**267.** Сэргээн засалтын үндэсний төв 2006 оны эхний хагаст 1561 хүнд протез, ортопедийн хэрэгслээр үйлчилж, 70773.3 сая төгрөгийн протез, ортопедийн хэрэгсэл үйлдвэрлэсний 22.9 хувийг нийгмийн халамжийн сангаас нөхөн төлсөн байна.

**268.** Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 20 гаруй нэгжид 437 эмч, ажилтан ажилладаг бөгөөд түүний 11 тасаг бүхий 450 ортой клиник эмнэлгийн хүүхдийн тасаг 30 ортой ажиллаж байна. Хүний эрхийн Үндэсний Комисс тус төвийн үйл ажиллагаанд 2006 онд шалгалт явуулахад хүүхдийн тасагт өвчтэй 26 (түүний 13 нь эрэгтэй) хүүхэд эмчлүүлж байсны 19 нь байнга амьдарч асруулдаг бөгөөд эдгээр хүүхэд иргэний баримт бичиггүй байжээ. Иймээс Хүний эрхийн Үндэсний Комисс эдгээр хүүхдийн эрх зөрчигдөж, эрсдэлд өртөж болзошгүй гэж үзсэн байна.

**269.** Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэн сүрьеэ зэрэг архаг халдварт өвчний халдвартай үеэс бусад тохиолдолд эрүүл иргэдтэй хамт сурч, боловсрох, мэргэжил эзэмших эрхтэй болно. Түүнчлэн Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлд “Боловсролын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн

<sup>11</sup> Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын тухай илтгэл, 2007. (ХЭҮК) хуудас 20–58

хөдөлмөрийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна”, мөн 43 дугаар зүйлд “хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг сурах нөхцөл, бололцоогоор төрөөс хангах” гэж хуульчилсан байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах хөтөлбөр (2004–2008)–ийг батлан хэрэгжүүлж байна. Энэ хөтөлбөрт хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургуульд суралцах нөхцөл бололцоог хангах, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тусгай сургуульд суралцуулах замаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүрийг ерөнхий боловсролын сургуульд хамруулан сургах бодлогыг тодорхойлсон байна.

Шведийн Олон улсын хөгжлийн агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй” сэдэвт сургалтад Архангай, Хөвсгөл аймаг, нийслэлийн Хан–Уул дүүргийн бага ангийн болон цэцэрлэгийн 852 багшийг хамруулж, тэдэнд шинэ арга зүй эзэмшүүлсэн байна. Багш бэлтгэдэг сургуулийн сургалтын хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн 32 цагийн хичээлийн хөтөлбөрийг боловсруулан сургалт явуулж байна.

**270.** Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Олон улсын АДРА байгууллага хамтран хэл яриа, сонсголын бэрхшээлтэй хүүхдэд зориулсан 3000 үгтэй “Дохионы хэлний толь бичиг”–ийг боловсруулж, түүнийг (1000 хувь) хэвлүүлэн олон нийтэд хүргэлээ. Дохионы хэлний анхан шатны сургалтыг 3 аймаг, багш бэлтгэдэг сургуулийн багш, оюутан, түүнчлэн цагдаагийн болон хүүхдийн байгууллагын ажилтан, эцэг эх, ерөнхий боловсролын сургуулийн сурагч зэрэг нийт 3000 гаруй хүнийг хамруулан зохион байгууллаа. Дохионы хэлний толь бичигт үндэслэн аймаг, нийслэлд дохионы хэлний сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөр, багш нарт зориулсан сургалтын гарын авлага боловсруулан гаргав. Энэхүү сургалтын хөтөлбөрийн дагуу аймаг, нийслэлийн дохионы хэлний сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулж, түүнд аймаг бүрээс 2–3 багшийг хамруулж, орон нутагт сургалт явуулах 65 хүний нөөцийг бүрдүүлсэн байна.

**271.** Олон улсын АДРА байгууллагатай хамтран харааны бэрхшээлтэй хүүхдийн сургалтын орчныг сайжруулах зорилгоор (17000 ам.долларын өртөг бүхий) аудио студийг байгуулан ашиглалтад оруулж, хүүхдэд зориулсан 30 төрлийн сургалтын CD материалыг (тус бүр 100 хувь) хэвлүүлэн 21 аймаг, 9 дүүрэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагад хүргүүлээ. Мөн НҮБ–ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгээр нийслэлийн хүүхдийн номын санд “Ярьдаг номын сан” бий болголоо.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Олон улсын дэмжлэг туслалцааны төлөөлөгчийн газрын хамтын ажиллагааны гэрээний дагуу 2006/2007 оны хичээлийн жилд харааны бэрхшээлтэй 75 хүүхдийг брайл цаас, таяг, бичгийн машин зэрэг 8000 гаруй еврогийн сургалтын хэрэглэгдэхүүнээр хангасан байна.

**272.** Түүнчлэн “Mongolian text to speech” програмыг боловсруулан холбогдох байгууллага болон нийтийн номын санд хүргүүлээ. Энэ компьютерийн програмын тусламжтайгаар мэдээлэл түгээх боломжийг нэмэгдүүлэхэд ихээхэн ач холбогдолтой арга хэмжээ боллоо. Эдгээр шинээр гарсан бүтээлийг орон нутгийн асуудал хариуцсан

ажилтны хоёр өдрийн сургалтын явцад таниулав.

**273.** Боловсролын тухай хуулиар хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээтэй уялдуулан нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг байгууллага тус бүрээр ялгавартай тогтоох бөгөөд аргачлалыг нь боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж байхаар хуульчилсны дагуу хөгжлийн бэрхшээлтэй нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээг шинэчлэхээр бэлтгэж байна. Хөгжлийн бэрхшээлтэй нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг ялгаатай тогтоосноор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургуульд суралцах бололцоог нэмэгдүүлэх, тэдэнд шаардлагатай тусгай хэрэглэгдэхүүнээр хангахад ач холбогдолтой арга хэмжээ болох юм.

**274.** Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч, боловсрох эрхийг бүрэн хангахад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах мэргэжилтэн, багшийн хүрэлцээ дутмаг, сургалтын хөтөлбөр, сургалтын модулийн боловсруулалт ердийн сургуульд суралцах нөхцөлд нийцэхгүй байх, сургалтын үнэлгээний аргачлал гараагүй, сургуулийн орчин, түүний тохижилт тэдний онцлог хэрэгцээнд тохирдоггүй байдал зэрэг хүчин зүйлс сөрөг нөлөө үзүүлж байна. Асрамжийн байгууллага 0–6 насны оюуны болон сэтгэцийн эмгэгтэй хүүхдэд зохих үйлчилгээг хүргэдэг хэдий ч 6–гаас дээш насны хүүхдэд үзүүлэх үйлчилгээг хэрхэн хүргэх асуудлыг шийдээгүй хэвээр байна.

**275.** Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд гэр бүл, олон нийтийн зүгээс хандах хандлагын өөрчлөлт, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бусадтай харилцах, өөрийгөө илэрхийлэх дадал, туршлага тэдний боловсрол эзэмших тэгш байдлыг хангахад сөргөөр нөлөөлж байна.

**276.** Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай, Боловсролын тухай, Барилгын тухай зэрэг хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээнд нийцсэн дэд бүтцийг хөгжүүлэхээр заасан байна. Гэхдээ Хүний эрхийн Үндэсний Комиссын 2007 оны илтгэлд төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжийн зүгээс сүүлийн хоёр жилийн хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай хэрэгцээнд нийцсэн орчин бүрдүүлэх, дэд бүтэц бий болгох чиглэлээр зарим арга хэмжээг эхлүүлсэн хэдий ч дорвитой үр дүнд хүрээгүй байна гэж дүгнэжээ.

Төрийн захиргааны төв байгууллагын удирдлага голдуу хоёроос дээш давхарт байрладаг бөгөөд тэднийг зорих хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ашиглах цахилгаан шат, бусад хэрэгсэл алга байна. Мөн ерөнхий боловсролын сургууль, соёл, урлагийн газар, нэгдсэн болон клиникийн эмнэлэг, дэлгүүр, үйлчилгээний зэрэг газарт хөгжлийн бэрхшээлтэй иргэд саадгүй нэвтрэх таатай орчин бүрдээгүйн дээр авто замын нэмэлт байгууламж баригдаагүй байна. Харин Монголын хүүхдийн ордон, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн гадна тэргэнцэртэй хүн орох, гарахад зориулсан байгууламжийг байгуулсан байна. Ерөнхий боловсролын 15, 80 дугаар сургуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэн суралцах зарим стандартын орчныг бүрдүүлсэн байна.

**277.** Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлд “телевизийн мэдээллийн нэвтрүүлгийг дохионы орчуулгатай гаргах”, Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 8 дугаар зүйлд “үндэстний цөөнх, эмэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлэг, давхаргын эрэлт хэрэгцээг

тэнцвэртэй хангахыг эрмэлзэх” гэж заасан байна. Гэвч Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа нийт 16 телевизийн мэдээллийн хөтөлбөр дохионы хэлний орчуулгагүй явж байна.

**278.** Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд амралт, чөлөөт цагийн болон спортын үйлчилгээнд чөлөөтэй хамрагдах орчин хараахан бүрдээгүй байна.

**Долоодугаар бүлэг. Боловсрол, чөлөөт цаг, соёлын арга хэмжээ**

*(28, 29, 31 дүгээр зүйл)*

**279.** Хүүхдийн боловсрол, чөлөөт цаг, соёлын арга хэмжээний талаар үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулсан мэдээллийг Монгол Улсын үндэсний хоёрдугаар илтгэлийн гуравдугаар бүлэгт буюу 11–15 дахь талд танилцуулсан болно.

**280.** Боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлд “боловсролыг тэргүүлэх салбар болгон хөгжүүлж, төрийн ивээл, зохицуулалт, төр, олон нийтийн хяналтад байлгана” гэж заажээ. Боловсрол олгохтой холбогдсон харилцааг Бага, дунд боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль зэрэг эрх зүйн актаар зохицуулж байна. Монгол Улсад боловсролын тогтолцоо нь албан ба албан бус боловсролын нэгдэл байх бөгөөд сургуулийн өмнөх болон бага, дунд, дээд боловсролоос бүрдэнэ. Албан сургалт нь өдөр, орой, эчнээ, экстернат зэрэг хэлбэртэй байж болно. Албан боловсролын агуулга, стандартыг хуульд заасан журмын дагуу тогтоох бөгөөд албан бус боловсролын агуулга чөлөөтэй байхаар хуульчилсан байна.

Боловсролын тухай хуулиар суралцагчаас хуульд заагаагүй төлбөр, хураамж авахыг хориглосон хэдий ч сургуулийн захиргаа, багш нар элдэв татвар, хураамж авдаг байдал олон хүүхдэд санхүүгийн бэрхшээл учруулж хүүхэд бүр боловсролын үйлчилгээг жигд хүртэх эрх зөрчигдөж, сурагчид сургуулийн орчинд хүчирхийлэлд өртөх явдал гарч байгааг арилгахад ихээхэн анхаарч байна.

Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд Боловсролын тухай хуульд 2006 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл санаа чиглэж байна. Энэ хуулиар боловсролын орчинд хүчирхийлэл, бие махбодын шийтгэл үйлдэх, сурагчдаас элдэв татвар, хураамж авах явдлыг хориглосон юм. Хүүхэд бүр 16 нас хүртлээ заавал суралцах ёстой бөгөөд төрийн өмчийн сургууль ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгодог. Хүүхдүүд авьяас чадвараа хөгжүүлэх, чөлөөт цагаа өнгөрүүлэх үйл ажиллагаанд сургуулийн барилга, анги танхимыг үнэ төлбөргүй ашиглах эрх эдэлдэг.

**281.** Боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, нэн ялангуяа хөдөөний хүүхдэд сургуульд суралцахад тулгарч байгаа бэрхшээлийг арилгах талаар Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Засгийн газар анхаарч ажиллалаа. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны байнгын хүчин чармайлт, олон улсын байгууллагуудын дэмжлэг тусламжийн дүнд суурь боловсролд хамрагдалтын бохир жин 2005 онд 92.3 хувь байснаас 2006 онд 93.7 хувь болж 1.4 хувийн өсөлт гарсан байна.

Ерөнхий боловсролын сургуулийн анги дүүргэлтийг зохих түвшинд байлгах, сургуулийг суралцагчдын амьдарч байгаа орчинд ойр байлгах асуудлыг шийдэх

зорилгоор Засгийн газар сургуулийн барилгыг шинээр барих, өргөтгөх, засварлах ажлыг Азийн хөгжлийн банк, Японы Засгийн газар, Нордикийн хөгжлийн сан зэрэг олон улсын хөгжлийн байгууллагын дэмжлэг туслалцаа болон дотоод эх үүсвэрт түшиглэн хэрэгжүүлж байна. Зөвхөн 2006 онд ерөнхий боловсролын сургуулийн суудал 7052-аар, цэцэрлэгийн ор 590-ээр нэмэгдлээ. Сургуулийн хичээлийн байрны нөхцөлийг сайжруулах, шинээр сургууль, цэцэрлэг барих, түүний халаалт, сантехникийн байгууламжийг шинэчлэх, цахилгааны найдвартай эх үүсвэрээр хангах талаар Хүүхдийн эрхийн хорооны өгсөн зөвлөмжийн дагуу төрөөс нэлээд арга хэмжээ авлаа. Гадаад, дотоодын санхүүгийн эх үүсвэрээр 100 гаруй сумын сургуулийн халаалтын байгууламжийг шинэчилж, 60 гаруй цэцэрлэг, 100 гаруй эмнэлгийг шинэчлэн засварласан байна. Тайлант 2005–2007 онд 74 сумын төвийг төвийн эрчим хүчний сүлжээнд холбож, 199 сумын дизель станцыг шинэчилсэн байна.

Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн зөвлөмжид дурдсан сурах бичгийн чанарыг сайжруулах ажил амжилттай хэрэгжиж байна. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас ерөнхий боловсролын сургуулийн сургалт 12 жилийн тогтолцоонд шилжиж байгаатай холбогдуулан шинэчлэн боловсруулсан сургалтын хөтөлбөрт нийцүүлэн сурах бичгийг зохиох, хэвлэх, түгээх ажлыг зохион байгуулж байна. Ерөнхий боловсролын сургуулийн 47 нэрийн сурах бичгийг 2006/2007 оны хичээлийн жилд 1.8 сая хувь хэвлүүлэн түгээсний зэрэгцээ шинээр 37 нэрийн 86 төрлийн сурах бичгийг хэвлэхээр сонгон шалгаруулсан нь нийт шинэчлэгдэх шаардлагатай сурах бичгийн 52 хувийг эзэлж байна.

**282.** Хэдийгээр Хүүхдийн эрхийн хорооны зөвлөмжид боловсролын хүртээмж, чанарыг сайжруулах талаар дурдсан бүхий л асуудлыг шийдвэрлэхийн төлөө Монгол Улсын Засгийн газар ихээхэн анхаарал тавьж байгаа хэдий ч сүүлийн үеийн манай байгаль, цаг агаар, эдийн засаг, нийгмийн хөгжлийн зарим тулгамдсан асуудал урган гарч, тэдгээрийг шийдэхэд бэрхшээл учирсаар байна.

**283.** Монгол Улсын Засгийн газар “Бичиг үсгийн боловсрол” үндэсний хөтөлбөр, “Хүүхдэд ээлтэй сургуулийг хөгжүүлэх бодлого”, “Боловсролын салбарыг 2006–2015 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө” зэрэг бодлогын баримт бичгийг боловсруулан гаргаад байна. Энэхүү ерөнхий төлөвлөгөө бол сургуулийн өмнөх, бага, дунд боловсрол, мэргэжлийн боловсролын хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх арга замыг тодорхойлж, түүнд шаардагдах дотоод, гадаад хөрөнгийн санхүүжилтийн эх үүсвэрийг баталгаажуулсан чухал баримт бичиг болсон юм.

**284.** Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын тушаалаар 2005 оноос багш нарт багшлах эрх олгох ажлыг зохион байгуулж эхэлсэн бөгөөд Багшийн ёсзүйн дүрэм зөрчсөн, хүүхдийн эрхийг зөрчсөн тохиолдолд багшлах эрхийг хасах хүртэл арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн болно. “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшид багшлах эрх олгох, хасах журам”, “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, Боловсролын газрын арга зүйч, албан бус боловсролын багшид мэргэжлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам”, “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын багш, холбогдох албан тушаалтны мэргэжил дээшлүүлэх журам”-ыг шинэчлэн боловсруулж байна.

**285.** Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны санаачилга, Засгийн газрын шийдвэрээр 2006 оноос “Боловсролын шинэчлэл–иргэний оролцоо” аяныг орон

даяар зохион байгууллаа. Энэхүү аяны хүрээнд Монгол Улс зах зээл, иргэний нийгэмд шилжсэнээс хойшх 16 жилийн хугацаанд боловсролын салбарт хэрэгжүүлсэн бодлого, өөрчлөлт шинэчлэлийн явц, үр дүн ямар байгааг сургууль, цэцэрлэг, нэгж байгууллага дээр судалж шинжлэх, танилцах, дүгнэлт гаргах, боловсролын талаар иргэд, эцэг эх, багш, боловсролын ажилтны санаа бодлыг сонсох, тэдэнд бодлого, зорилго таниулах, харилцан ярилцах замаар боловсролын цаашдын хөгжлийн арга хэмжээг тодорхойлох, “Монголын багш нарын улсын анхдугаар зөвлөгөөн” –д бэлтгэхэд чиглэсэн юм.

Засгийн газраас 2006–2015 ба 2021 он хүртэл баримтлах боловсролын хөгжлийн бодлого, стратеги, төлөвлөгөөг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын эх үүсвэр нэмэгдсэн энэ цаг үед багш нарын өмнө тулгамдсан зорилгыг шийдвэрлэх арга замын талаар хэлэлцэж, зөвлөлдөх зорилго бүхий “Багш нарын улсын анхдугаар зөвлөгөөн” –ийг (2007 оны 4 дүгээр сарын 26–27–ны өдрүүдэд) Улаанбаатар хотод амжилттай зохион байгуулав. Багш нарын анхдугаар зөвлөгөөнөөс гаргасан зөвлөмж, уриалгыг хэрэгжүүлэх зорилгоор багшийн хангамжийг сайжруулах чиглэлээр 2007–2008 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэллээ.

**286.** Дотоодын нийт бүтээгдэхүүний 7 орчим хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг боловсролын салбарт зарцуулж байна. Боловсролын санхүүжилт 2004 онд 145.9 тэрбум төгрөг байсан бол 2006 онд 195.2 тэрбум төгрөгт хүрч 33.8 хувиар өссөн байна. Боловсролын салбарын нийт төсвийн 18–20 хувийг сургуулийн өмнөх боловсролд, 35–40 хувийг ерөнхий боловсролд, 3 орчим хувийг сургуулийн дотуур байрны зардалд, үлдсэн хувийг мэргэжлийн боловсрол, удирдлагын зардалд зарцуулж байна.

Сүүлийн жилүүдэд боловсролын салбарт хувийн салбарын болон олон улсын байгууллагын санхүүжилт нэмэгдэж байна. Улсын Их Хурлаар батлагдсан Монгол Улсын 2007 оны төсвийн тодотголоор боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын 2007 оны төсвийн багц 270.6 тэрбум төгрөгт хүрч 2007 оны батлагдсан төсвөөс 34.4 тэрбум төгрөг буюу 14.5 хувиар нэмэгдсэн байна. Тухайлбал, боловсролын салбарын төсөв 21.2 тэрбум төгрөгөөр, соёл, урлагийн салбарын төсөв 2.6 тэрбум төгрөгөөр, шинжлэх ухааны салбарын төсөв 356.1 сая төгрөгөөр, улсын төсвийн хөрөнгө оруулалт, их засварын санхүүжилтийн төсөв 10.3 тэрбум төгрөгөөр нэмэгдлээ.

Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2006 оны 12 дугаар сарын 8–ны өдрийн) хуулиар сум, тосгон, багийн сургууль, цэцэрлэгийн багшид 5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа байгууллагаас нь олгож байхаар шийдвэрлэсний дагуу багш нарын нэг удаагийн мөнгөн тэтгэмжид зориулан 2007 оны төсөвт 8.2 тэрбум төгрөгийг баталж өгсөн байна.

#### **А. Сургуулийн өмнөх боловсрол**

**287.** Бага, дунд боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлд “цэцэрлэг нь хоёр наснаас сургуульд орох хүртэлх хугацаанд хүүхдийн бие бялдар, оюун санааг хөгжүүлж, төлөвшүүлэх сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллага мөн”, “цэцэрлэг нь боловсролын стандартын дагуу хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлнэ” гэж заасан байна.

**288.** Монгол Улсад 2006/2007 оны хичээлийн жилд 10 ясли, 742 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж, эдгээрт сургуулийн өмнөх боловсролын насны нийт хүүхдийн 60 гаруй хувь буюу 94.7 мянган хүүхэд хамрагдаж байна. Энэ үзүүлэлтийг 2003/2004 оны хичээлийн жилтэй харьцуулахад 5000 гаруй хүүхдээр өссөн байна.

Нийт цэцэрлэгийн 87 хувь нь төрийн өмчийн, 8 хувь нь хувийн, үлдсэн нь байгууллагын мэдлийн цэцэрлэг байна. Нийт цэцэрлэгийн 98 орчим хувь нь ердийн цэцэрлэг бөгөөд эдгээр нь хамран сургах тойргийнхоо хүүхдийг жил бүрийн 9 дүгээр сарын 1 нээс дараа жилийн 6 дугаар сарын нэгэн хүртэлх хугацаанд ажлын таван өдөр ажиллаж, хүүхдийн хэл яриаг хөгжүүлэх, математикийн энгийн төсөөллийг ойлгуулах, дуу хөгжим, бие бялдар, дүрслэх урлагийн зэрэг сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг батлагдсан стандартын дагуу явуулж байна. Ердийн цэцэрлэг нь яслийн, бага, дунд, ахлах, бэлтгэл болон холимог бүлэгтэй бөгөөд эдгээр цэцэрлэгт нийт 3186 бүлэг, үүнээс 664 бэлтгэл бүлэг ажиллаж байна.

**289.** Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны тушаалаар батлагдсан Цэцэрлэгийн дүрэмд сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагааны чиглэл, сургалтын агуулга, арга зүйн шинэчлэлийг тусгасан байна. Энэ дүрмээр бага насны хүүхдийн эрх, хөгжлийг хангахад цэцэрлэгийн гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны үндсэн чиглэл, багшийн эрх, үүрэг, сургалтын хөтөлбөр, байр, тавилга хэрэгсэл, орчин, тоглоом, хичээлийн хэрэгсэлд тавигдах стандартыг тодорхойлсон юм.

Мөн цэцэрлэгийн зөвлөлийг багш, ажилтан, эцэг, эх, бусад байгууллагын 9–11 гишүүний төлөөлөлтэйгээр 3 жилийн хугацаагаар сонгодог. Цэцэрлэгийн зөвлөл хөгжлийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санал өгөх, цэцэрлэгийн дэг журам, дотоод зохион байгуулалтын хэлбэрийг тодорхойлох, цэцэрлэгийн үйл ажиллагааны тайлан хэлэлцэх, үнэлэлт, дүгнэлт өгөх, сургалтын чанар, хүүхэд төлөвшүүлэх, хамгаалах, хөгжүүлэх ажлын үр дүн, түвшинг сайжруулах талаар цэцэрлэгийн удирдлага болон үүсгэн байгуулагчид санал тавих, эрхлэгчийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих, дэмжлэг үзүүлэх, багш, хүүхэд, ажилтны эрх ашгийг хамгаалах үйл ажиллагааг явуулдаг.

**290.** Сургуулийн өмнөх боловсролын сургалтыг цэцэрлэгийн болон хувилбарт гэсэн үндсэн хоёр хэлбэрээр явуулдаг. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэхэд хувилбарт сургалтын хэлбэр чухал үүрэг гүйцэтгэсээр байна. Хувилбарт сургалт хэмээх ойлголтод гэр цэцэрлэг, ээлжийн бүлэг, цагийн сургалт, малчдын хүүхдэд зориулсан зуны нүүдлийн сургалт зэргийг багтааж байна. Тайлант хугацаанд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ авсан хүүхдийн 20 орчим хувь нь хувилбарт сургалтад хамрагдсан байна. Хувилбарт сургалтыг цэцэрлэг өөрийн хамран сургах тойрогтоо зохион байгуулах үүрэгтэй бөгөөд шаардлагатай зардлыг орон нутгийн төсвөөс гаргадаг.

Сургалтын хөтөлбөрийг олон хувилбартай боловсруулан ашиглаж байна<sup>12</sup>. Сүүлийн арваад жилд сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 11 хувиар нэмэгдэж, 41.1 хувьд хүрсэн байна.<sup>13</sup>

<sup>12</sup> Монгол Улсын Засгийн газар, Хүүхдийн асуудлаарх үндэсний дээд хэмжээний чуулга уулзалт, Улаанбаатар 2004. 44 дэх тал

<sup>13</sup> Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны 2006 оны тайлан



**291.** Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй Боловсролын салбарын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд 2006 онд цэцэрлэгүүдэд 189.0 мянган ам. долларын хөрөнгө оруулалт хийж, сургалтын орчныг сайжруулав. Хүүхдийн оюун ухаан, сэтгэхүй, хэл яриа, бие бялдрыг хөгжүүлэхэд зориулсан 2006–2007 онд 150 цэцэрлэгт эрүүл ахуй, аюулгүй байдалд нийцсэн тус бүр 1260 ам. долларын үнэ бүхий 56 нэр төрлийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом, наадгайг нийлүүллээ.

**292.** Зарим аймгийн төв, нийслэлд сувиллын арав орчим, асрамжийн гурван цэцэрлэг ажиллаж байна. Асрамжийн болон сувиллын цэцэрлэгт мөрдөх журмыг боловсролын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтоож байна.

**293.** Сургуулийн өмнөх боловсролын стандартыг шинэчлэн хэрэгжүүлж байна. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын үлгэрчилсэн цөм хөтөлбөрийг 2001 онд боловсруулж гаргасан бөгөөд хүүхдийн насыг 0–2, 3–5, 6–7 гэсэн үечлэлд ангилж, насны ангилал бүрээр хөгжүүлэх үйл ажиллагааг үндсэн 4 чиглэлд хуваан хүүхдийн бүх талын хөгжилд анхаарч байна. Сургалтын шинэ стандартын дагуу сургуулийн өмнөх боловсролын үндэсний ба орон нутгийн сургагч багш нарыг бэлтгэх сургалтыг бүсчлэн зохион байгуулж, түүнд 21 аймаг, нийслэлийн 282 хүнийг хамруулав. Тусгай боловсролын чиглэлээр 5 удаагийн сургалтыг зохион байгуулж, 206 багшийн мэдлэг, чадварыг дээшлүүлэв.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам бага насны хүүхдийн хөгжлийн стандартыг боловсруулж байна. Сургуулийн өмнөх боловсролын хамралтын хүрээг цэцэрлэгээр хязгаарлахгүйгээр гэр бүл, орон нутгийн хэмжээнд бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих ажлыг үр дүнтэй зохион байгуулах, чанаржуулахад бага насны хүүхдийн хөгжлийн стандартын агуулга чиглэж байна.

**294.** Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 2007 оны байдлаар эрхлэгч, багш, туслах багш болон үйлчилгээний ажилтан зэрэг нийт 12000 орчим хүн ажиллаж байгаагийн 3700 буюу 30.8 хувь нь багш байна. Цэцэрлэгийн багшийн багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох асуудлыг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцдаг бөгөөд цэцэрлэгийн багшийг боловсролын их сургууль, дээд сургууль, коллежид бэлтгэж байна.

**295.** Цэцэрлэгийн хүүхдийн хоол тэжээлийн нормыг 2006 онд шинэчлэн баталж мөрдүүлсэн байна. Хүүхдийн хоолны зардлын тал хувийг улсын төсвөөс, үлдсэн хувийг хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчаас төлж байхаар зохицуулсан байна.

**296.** Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг Засгийн газар жил бүр шинэчлэн тогтоодог. Цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативыг 2007 онд нийслэлд цалингийн зардалд 210100 төгрөг, бусад хувьсах зардалд 26500 төгрөг; аймгийн төвд цалингийн зардалд 217300 төгрөг, бусад хувьсах зардалд 29700, сумдад цалингийн зардалд 259100 төгрөг, бусад хувьсах зардалд 37100 төгрөг тус тус байхаар тогтоосон байна.

**297.** Сургуулийн өмнөх боловсролын салбарт 2005 онд 25.2 тэрбум төгрөг, 2006 онд 29.8 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Төсвөөс хуваарилсан хөрөнгийн ихэнх хувийг

халаалт, гэрэл цахилгаан, цалин болон хүүхдийн хоолны зардалд зарцуулж байна.

**298.** Сургуулийн өмнөх байгууллагын үйл ажиллагаа, орчныг сайжруулахад олон улсын байгууллагын дэмжлэг, туслалцаа чухал үүргийг гүйцэтгэж байна. Тухайлбал, Европын Холбооны Европын комисс, Их Британий Хүүхдийг ивээх сангийн санхүүжилтээр “Сургуулийн өмнөх болон бага боловсролын чанарыг сайжруулах” төслийг 7 аймаг, Улаанбаатар хотын 2 дүүргийг хамруулан хэрэгжүүлж байна. Энэ төслийн хүрээнд 2006 онд 7 аймгийн 15 сумын цэцэрлэгийг гэр, тоглоом наадгай, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангасан байна.

**299.** Гэр хороолол, алслагдсан бүс нутгийн малчин өрх, алт гар аргаар олборлож байгаа газруудад хүүхэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдах боломж хязгаарагдмал хэвээр байна. Хөдөөгийн хүүхдийн цэцэрлэгт хамрагдалт бага байгаа нь нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг малчид малын бэлчээр даган нүүдэллэн амьдардаг уламжлалтай нэг талаар холбоотой юм. Бэлчээрийн хомсдол, цөлжилтийн улмаас малчин өрх улам алс, бие биеэсээ хол газар амьдрахад хүрч байгаагаас тэдэнд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ үзүүлэх өртөг зардлыг улам нэмэгдүүлж байна. Ерээд оны эхээр сургууль завсардаж хөдөө мал маллахаар гарсан хүүхдүүд насанд хүрч, өрх тусгаарлан амьдрал зохиож эхэлж байна. Тэд хүүхдийнхээ хөгжил, боловсролд бага анхаарах болсноос хөдөөгийн бага насны хүүхдийн хөгжилд сөрөг тал гарах магадлал өндөр байна. Иймд хөдөөгийн залуу эцэг, эхийн үр хүүхдээ асрах мэдлэг, боловсролд зориуд анхаарах шаардлагатай байна.

**300.** Түүнчлэн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын орчны тохижилт, хоол тэжээлийн чанарыг сайжруулахад эцэг, эх, олон нийтийн байгууллагын санаачилга, оролцоо ихээхэн үгүйлэгдэж байна.

**301.** Цаашид цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, сургалтын чанарыг сайжруулах чиглэлээр тусгайлан анхаарал хандуулах шаардлага урган гарч байна.

## **Б. Бага, дунд боловсрол**

**302.** Бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөр, түүний агуулгыг олон улсын жишигт ойртуулах чиглэлээр Бага, дунд боловсролын тухай хуульд 2006 онд оруулсан нэмэлтийн дагуу “бага боловсролыг 6, суурь боловсролыг 9, бүрэн дунд боловсролыг 12 жилд тус тус эзэмшүүлэх” –ээр заасан байна.

Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх эрх зүйн орчныг шинэчлэхийн зэрэгцээ сургалтын стандарт, төлөвлөгөө, сургалтын орчин, багшийн боловсрол, түүний хангамж, үйл ажиллагааны санхүүжилт, ялангуяа бага насны хүүхдийг асран хамгаалах ээлтэй орчин бүрдүүлэх зэрэг ажлыг цогц байдлаар хэрэгжүүлэх эрмэлзэлтэй ажиллаж байна.

Ерөнхий боловсролын 12 жилийн сургалттай сургуулийн сургалтын төлөвлөгөөг боловсруулж, түүнийг ахлах, дунд ангид хоёр хувилбартай байхаар зохиолоо. Мөн цөөн анги, бүлэгтэй сургуульд мөрдүүлэх сургалтын төлөвлөгөө, олон анги, бүлэгтэй сургуульд байгалийн болон нийгмийн ухааны нэгдмэл хичээлийг зааж, түүнийг сонгон судлах бололцоог нээж өглөө.

**303.** Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлд “үндэстний цөөнхийн боловсрол

эзэмших, соёл, зан заншлаа өвлөх, сургуулийн орчинд төрөлх хэлээрээ харилцах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах” ажлыг аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхэд хамааруулсан байна.

Казах, тува хүүхдийн боловсролд тэгш хамрагдах бололцоог нэмэгдүүлэхэд анхаарч байна.<sup>14</sup> Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам казак хэлний боловсролын стандарт, хөтөлбөрийг Баян-Өлгий аймгийн Боловсрол, соёлын газартай хамтран боловсруулж байна. Түүнчлэн тува хэлний сургалтын хөтөлбөрийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын тушаалаар батлан хэрэгжүүлж эхэллээ.

**304.** Өнгөрсөн 2006/2007 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын нийт 742 сургууль ажиллаж, түүний 71 нь бага сургууль, 172 нь 9 жилийн сургууль, 499 нь 11 жилийн сургууль байна. Ерөнхий боловсролын 211 сургуульд орой, эчнээ анги хичээллэж, өдрийн цагаар тогтмол суралцах боломжгүй өсвөр насны хүүхдийн боловсролыг ахиулах нөхцөлийг бүрдүүлж байна.

**305.** Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй Боловсролын салбарын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд ерөнхий боловсролын 180 сургуульд байгалийн ухааны лаборатор, бүрэн дунд боловсролын 150 сургуульд мэргэжлийн чиг баримжаа олгох зориулалтын тоног төхөөрөмж нийлүүллээ. Мөн ерөнхий боловсролын 50 цогцолбор сургуульд 150 сая төгрөгийн ном, гарын авлагыг багш, сурагчдад зориулан олголоо.

Түүнчлэн НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр явуулын 21 багшид мотоцикл, 10 цэцэрлэгт тоглоом наадгай, сургалтын хэрэглэгдэхүүн, ном, гарын авлага нийлүүлсэн байна. Дэлхийн банкны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа “Хөдөөгийн боловсролыг дэмжих (READ)” төслийн хүрээнд 5 аймгийн ерөнхий боловсролын сургуулийн бага ангид номын сан байгуулах, багш нарыг сургах ажлыг амжилттай зохион байгууллаа. Бусад аймгийн ерөнхий боловсролын сургуулийн бага ангийг 2007/2008 оны хичээлийн жилээс эхлэн номын сантай болгосон байна. Энэ төслийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих 33 хэлээр хөрвүүлсэн интернэт номын сангийн монгол хувилбарыг хөдөөгийн зарим сургуульд туршиж байна.

**306.** Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын дүнгийн нууцлалыг сайжруулах зорилгоор журналыг анги удирдсан багшийн дэвтэр гэсэн загварт оруулсан байна.

**307.** Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2004 оны 190 дүгээр тушаалаар зөвшөөрсөн Хүүхдэд ээлтэй сургуулийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж байна. Энэ баримт бичигт сургуулийн орчинд хүүхдийн үндсэн эрхийг бүрэн хангахад чиглэсэн үйл ажиллагааг тодорхойлсон болно. Монгол Улсын Ерөнхийлөгчийн өгсөн зөвлөмжийн дагуу 2006/2007 оны хичээлийн жилээс сургалтын төлөвлөгөөнд сурагчдыг зөв төлөвшүүлэх, нийгмийн харилцаа, үнэт зүйлсийг таниулахад чиглэсэн “Иргэний боловсрол” хичээл оруулах боллоо.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад замын хөдөлгөөний дүрмийн талаарх ойлголт өгөх, хөдөлгөөнд соёлтой, зөв боловсон оролцдог дадал хэвшүүлэх,

<sup>14</sup> Казах хүүхдийн боловсролын байдлын дүн шинжилгээ, Их Британий Хүүхдийг ивээх сан– 2005

осол гэмтэлд орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Замын хөдөлгөөний соёл” сургалтын хөтөлбөрийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2006 оны 276 дугаар тушаалаар батлуулж, замын хөдөлгөөний хичээл заах багш нарт зориулсан зөвлөмжийг боловсруулан гаргаж, Замын цагдаагийн газартай хамтран ерөнхий боловсролын сургуулийн 1–3 дугаар ангид туршилтын журмаар сургалт явуулж эхэлсэн байна. Үүнтэй холбогдуулан ерөнхий боловсролын сургуулиудад замын хөдөлгөөний хичээлийн кабинетыг байгуулж байна.

Мөн газар зүй, түүхийн газрын зураг, атласыг сургалтын зориулалтаар зохиолгож, түүнийг хэвлүүлэн ерөнхий боловсролын сургуулиудад хүргүүлэхэд нийтдээ 70 шахам сая төгрөг зарцуулсан байна. Монголын үндэсний олон нийтийн телевизтэй хамтран “Монголын нууц товчоо” зохиолоор DVD хийж, ерөнхий боловсролын сургуулиудад тархааж байна.

**308.** Сургалтын шинэ стандарт, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багш нарын чадавхийг хөгжүүлэх, ажлын ачааллыг жигдрүүлэх, байнга суралцах орчныг сургуульд бүрдүүлэхэд анхаарч байна. Багшийн хүрэлцээ хангамж, нийгмийн асуудлыг сайжруулахад чиглэсэн бодлого, стратегийг томъёолох, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох, багшийн цалин хангамж, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх, багш мэргэжлээр элсэгчдийн тоо, чанарыг дээшлүүлэх, багш нарын мэргэжил, боловсролыг гадаад, дотоодод дээшлүүлэх сургалтыг зохион байгуулж байна.

Зөвхөн 2006/2007 оны хичээлийн жилд 18.6 мянган багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулж, үүнээс 1114 багш үндэсний хэмжээний төвлөрсөн сургалтад 2423 багш бүсийн сургалтад 6703 багш орон нутгийн сургалтад тус тус хамрагдсанаар Монгол Улсын боловсролыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд тавьсан зорилт ерөнхийдөө биелсэн байна.

БНСУ, Япон, БНХАУ, Тайланд, Вьетнам, Канад, Голланд, Турк зэрэг улс оронд зохион байгуулсан мэргэжил дээшлүүлэх сургалтад сургууль, цэцэрлэгийн удирдах ажилтан 150 багшийг оролцуулсан байна.

**309.** Ерөнхий боловсролын сургуульд нийт 22900 багш ажиллаж, 2006/2007 оны хичээлийн жилийн байдлаар ерөнхий боловсролын сургуулийн нэг багшид 23.7 сурагч, харин бага сургуулийн нэг багшид 31.7 сурагч ногдож байна.

**310.** Сургуулийн номын сангаар дамжуулан 2006/2007 оны хичээлийн жилд 347.4 мянган сурах бичгийг эмзэг бүлгийн өрхийн хүүхдэд олгож, түүнд 1.2 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Ерөнхий боловсролын сургуулийн дөрвөн хүүхдийн нэг нь сурах бичгийг үнэ төлбөргүйгээр хэрэглэж байна.

### **В.Албан бус боловсрол**

**311.** Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас бага, дунд боловсролын 25 стандартыг боловсруулан Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвөөр батлуулах арга хэмжээ авлаа. Эдгээр стандартын хүрээнд хүүхдэд боловсролыг дүйцүүлэн эзэмших боломж, нөхцөлийг олгож байна.

**312.** Хүүхдийн эрхийн хороо хөдөө орон нутагт сургууль завсардалтыг багасгах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүч чармайлтаа дайчлахыг Засгийн газарт зөвлөсөн

билээ. Өнгөрсөн 2006/2007 оны хичээлийн жилд дүйцсэн хөтөлбөрийн сургалтад 7–15 насны 4372 хүүхэд, бичиг үсгийн боловсрол олгох сургалтад 4837 насанд хүрэгч, мэргэжлийн чиг баримжаа олгох, амьдрах ухааны сургалтад 12747 хүн хамрагдсан байна.

Албан бус боловсрол, зайны сургалтын үндэсний төвөөс суралцагчдад зориулан бичиг үсгийн сурах бичиг, 24 төрлийн дүйцсэн сургалтын модуль, “Амьдрах ухаан”-ы хичээлийн 39 хэрэглэгдэхүүн, 7 төрлийн дүрс бичлэгийн кино бүтээж, эдгээрийг CD хэлбэрт оруулан мянган хувь хувилж, аймаг, сумын албан бус боловсролын Гэгээрлийн төвд түгээсэн явдал бүх нийтийн боловсролын хүртээмж, чанарт сайнаар нөлөөлж байна.

“ТВ–25”телевизтэй гэрээ байгуулж, ерөнхий боловсролын сургуулийн 20 төрлийн хичээл, сургалт, танин мэдэхүйн 80 удаагийн нэвтрүүлэг бэлтгэн орон даяар цацсан явдал багш нарыг сургалтын идэвхитэй арга зүйд суралцах, улмаар сурагч, эцэг, эхчүүд хэрэгцээт мэдээллээ олж авах боломжийг нээсэн байна.

**313.** Хөдөөд бага насны хүүхэд сургууль завсардаж байгаа шалтгааны нэг бол сургуулийн дотуур байрны хүртээмжийн асуудал юм. Дотуур байрыг шинээр барих, өргөтгөх, засварлах ажилд улсын төсвийн болон бусад хөрөнгийн эх үүсвэрийг ашигласнаар дотуур байрны хүүхдийн тоо 2002 онд 33.7 мянга байсан бол 2005 онд 41.1 мянгад хүрч 22 хувиар өссөн байна. *Өөрөөр хэлбэл*, дотуур байранд суухаар хүсэлт гаргасан нийт хүүхдийн 84.0 хувийг хангаж байна.

**314.** Өнгөрсөн 2005/2006 оны хичээлийн жилд 7–15 насны 12300 хүүхэд сургууль завсардсаны 61 хувийг эрэгтэй хүүхэд эзэлж байна.

**315.** Албан бус боловсролын сургалтын чанарыг сайжруулах, сургалтад хамрагчдын сурах сонирхол, сургалтын таатай орчныг бүрдүүлэх шаардлага байна.

### **Г. Мэргэжлийн боловсрол**

**316.** Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад тавих нийтлэг шаардлагыг шинээр боловсрууллаа. Энэхүү нийтлэг шаардлагын дагуу мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага (Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, шаталсан сургалттай коллеж, сургууль) шинээр байгуулах, өөрчлөх, тусгай зөвшөөрөл олгох, аттестатчлах, магадлан итгэмжлэх болон шинэ мэргэжлээр сургалт эрхлэхтэй холбогдсон дүгнэлт гаргахаар ажиллаж байна.

**317.** Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас дунд сургууль болон техник мэргэжлийн боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт тусгах зориулалттай “Бизнес, аж ахуй эрхлэх зан заншил, соёлыг хүүхэд, залуучуудад эзэмшүүлэх” сэдвээр боловсруулсан сургалтын иж бүрэн модулийг орчуулан, монголын нөхцөлд тохируулан туршилтын журмаар 2006/2007 оны хичээлийн жилээс мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн 5 төв, ерөнхий боловсролын 15 дунд сургуульд туршиж эхэллээ.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг сурталчлах “Хөгжлийн орц” аяныг 2007 оны 5 дугаар сард орон даяар зохион явууллаа. Энэхүү аян мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг сурталчлах, ажил олгогч болон сургалтын байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэсэн юм. Аянд хэвлэл мэдээллийн байгууллагууд идэвхитэй оролцсон бөгөөд аяныг үргэлжлүүлэхээр төлөвлөж байна. Энэ хүрээнд мэргэжлийн сургуулиуд

өөрийн сургууль, мэргэжлээ сурталчлах ажлыг тусгай хөтөлбөрөөр зохион байгуулах төдийгүй радио, телевизээр нэвтрүүлэх, сонин хэвлэлд нийтлүүлэх мэргэжлийн боловсрол, сургалтын ажлын ухуулга, сурталчилгааг тогтмол явуулна.

**318.** Бүс нутагт жижиг, дунд үйлдвэрийн цахилгаанчин, цахилгааны техникч бэлтгэх зорилгоор Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгээс “Цахилгаан станцын ажилчдын сургалт” төслийн хүрээнд Завхан аймаг дахь Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд 73000 ам. долларын, Японы Засгийн газрын “Өвсний үндэс” хөтөлбөрийн хүрээнд Өвөрхангай аймаг дахь Технологийн сургуульд 90.0 мянган ам. долларын тусламж үзүүлсэн байна.

Францын “Наадам” төрийн бус байгууллагаас 3.5 мянган ам. долларын хөрөнгөөр Дорнод аймаг дахь шаталсан сургалттай техник-технологийн сургуульд хоол үйлдвэрлэлийн дадлагын газрыг тохижуулсан байна. Сургууль дулааны хэмнэлт, өөрийн үйл ажиллагааны орлогоор чийрэгжүүлэлтийн танхим, интернэт кафе, үсчин, гоо сайхны дадлагын газар, дотуур байрны засварт 9.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн байна.

**319.** Ойрын жилүүдэд 2500 орчим хүнд барилгын мэргэжил эзэмшүүлж, ажлын байртай болгохоор ажиллаж байна. Азийн хөгжлийн банк дахь Ядуурлыг бууруулах Японы сангийн буцалтгүй тусламжаар ажилгүй хүмүүсийг барилгын салбарт хөдөлмөр эрхлэхэд бэлтгэх албан бус сургалтын тогтолцоог дэмжих төслийн үйл ажиллагааг эхлүүллээ. Энэ төслийн шугамаар сургалтын 9 төвийг сонгон бэхжүүлж, сургалтын агуулга, арга зүйг сайжруулж, барилгын 30 компанитай хамтран ажиллах болно.

АНУ-ын Мянганы сорилтын сангаас мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжиж 25 сая ам.долларын өртөг бүхий төсөл хэрэгжүүлэхээр боллоо. Буцалтгүй тусламжийн төслийг хэрэгжүүлэх албан ёсны гэрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч, АНУ-ын Ерөнхийлөгч нар 2007 оны 10 дугаар сард гарын үсэг зурж, төслийн санхүүжилтийг 2008 оны дундуур олгохоор тохирсон байна.

Төсөлд манай орны мэргэжлийн сургалт, техникийн боловсролын тогтолцоог хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд тохируулан шинэчлэх эрх зүйн орчин бүрдүүлэх, мэргэжлийн боловсрол олгох байгууллагад ур чадварт суурилсан сургалтын технологи нэвтрүүлэх, багш нарыг сургах, мэргэжлийн ур чадварын нэгдсэн стандарт тогтоож мөрдүүлэх, зах зээлд эрэлттэй мэргэжлийн сургалтын баазыг бэхжүүлэх, хүүхэд, залуучуудад мэргэжлийн баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээний сүлжээ байгуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

**320.** Өнгөрсөн хугацаанд мэргэжилтэй ажилчдын тоог нэмэгдүүлэх чиглэлээр анхаарч ажилласнаар суралцагчдын тоо жилээс жилд нэмэгдэж байна. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцагчдад 2007/2008 оны хичээлийн жилээс эхлэн сар тутам 23000 төгрөгийн тэтгэлэг олгох бөгөөд энэхүү тэтгэлэгт 24.7 мянган суралцагч хамрагдаж байна.

**321.** Бүсийн төвийн мэргэжлийн сургалтын байгууллагыг бэхжүүлснээр орон нутгийг мэргэжилтэй чадварлаг ажилтнаар хангах боломж өргөжих эхлэл тавигдлаа. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн 24 төвийн дадлагын байрыг иж бүрэн засварлаж, тоног төхөөрөмжөөр хангахад зориулан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2006 онд

1.0 тэрбум төгрөгийн санхүүжилт хийсэн нь 1990 оноос хойш тус салбарт улсын төсвөөс олгосон хамгийн их хөрөнгө оруулалт болсон байна.

**322.** Зах зээлийн шилжилтийн эхний жилүүдэд барилга, аж үйлдвэр, газар тариалангийн зэрэг салбарын үйлдвэрлэл саарснаас мэргэжилтэй ажилчдын хэрэгцээ багасаж, тэдний нийгмийн үнэлэмж буурсан, дээд боловсролыг дээгүүр тавих болсон, улмаар мэргэжлийн боловсрол олгох сургалтын тухай мэдээлэл олон нийтэд төдийлөн хүртээмжтэй хүрдэггүй, бас мэргэжлийн ажилчдын цалин хөлс их биш байдал эдүгээ мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх ажилд нэлээд бэрхшээл учруулж байна.

Нөгөөтэйгүүр мэргэжлийн боловсролын сургуульд элсэгчид суурь боловсрол эзэмшсэн байхыг шаарддаг явдал сургууль завсардсан буюу бага боловсролтой хүүхэд, өсвөр үеийнхний сурах боломжийг хязгаарлахад нөлөөлж байна.

### **Дээд боловсрол**

**323.** Дунд сургууль төгсөх сурагчид хоёр шаттай сургууль төгсөх болон их, дээд сургуульд элсэх шалгалт өгдөг байсан журмыг 2005/2006 оны хичээлийн жилээс өөрчилж, хүүхэд бүр өөрийнхээ сурсан мэдсэний хэр хэмжээгээр их, дээд сургуульд элсэх өргөн боломж олгох нэг шатлалтай тогтолцоонд шилжүүлсэн байна. Энэхүү тогтолцоо дээд боловсролын сургалтын байгууллагын тоо хэт олширсон өнөөгийн нөхцөлд иргэд, дунд сургууль төгсөгчид хүссэн сургууль, мэргэжлээ чөлөөтэй сонгох боломжийг өргөтгөх, улмаар шалгуулагч, элсэгчдэд учирч буй хүндрэл, ялангуяа үнэлгээний субъектив хандлагын нөлөөллийг арилгахад шинэлэг хэлбэрийн ажил болсон байна.

**324.** Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 28 дугаар зүйлийн “Хүн бүр чадвартаа түшиглэн дээд боловсрол эзэмших бололцоог шаардлагатай бүх арга замаар хангах” гэсэн заалтыг хэрэгжүүлэхийн төлөө Засгийн газар нээлттэй бодлого баримталж ирсний дүнд эдүгээ манай улсын төрийн ба төрийн бус өмчийн 130 гаруй их, дээд сургуульд 142 мянган залуус суралцаж байгааг харж болох юм. Дээд боловсрол эзэмших тэгш боломжийг хангахад төрийн сангийн зээл ихээхэн үүрэг гүйцэтгэж байна. Засгийн газраас сургалтын төрийн сангаар дамжуулан их, дээд сургуульд суралцагчдад сургалтын хөнгөлөлттэй зээл болон сургалтын тэтгэлэг, буцалтгүй тусламж олгож, санхүүгийн дэмжлэг үзүүлж байна.

Өнгөрсөн 2006/2007 оны хичээлийн жилд сургалтын төрийн сангийн зээлийн хөтөлбөрт 11 мянган оюутан, буцалтгүй тусламжийн хөтөлбөрт 17.4 мянган оюутан, мөн төрийн албан хаагчийн гэр бүлийн суралцагчид үзүүлэх хөнгөлөлтөд 18.5 мянган оюутан тус тус хамрагдсан байна. Мөн арилжааны банк, хувийн хэвшлийн томоохон аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллагууд сурлага сайтай боловч амьдралын түвшин доогуур оюутан нарт тэтгэлэг олгох хэлбэр нэлээд өргөжиж байна.

Гэсэн хэдий ч дээд боловсролын чанарыг сайжруулах, дээд мэргэжлийн хөрвөх чадварыг дээшлүүлэх, тэднийг ажлын байраар хангах зэрэг анхаарал татсан зүйл нэлээд байгаад Засгийн газар дүгнэлт хийж байна.

**Е. Амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх, соёлын амьдрал болон урлан бүтээх үйл ажиллагаа**

*(31 дүгээр зүйл)*

**325.** Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлд зааснаар “хүүхдийг хөгжүүлэх, тэдний эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий хүүхдийн сургалт хүмүүжил, амралт, хэвлэл, мэдээллийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлэх” үүргийг Засгийн газар хүлээж байна. Хүүхдийн чөлөөт цаг, хөгжил, төлөвшилд хамаарах чиг үүргийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам болон Эрүүл мэндийн яам, аймаг, нийслэлийн Засаг дарга голлон хэрэгжүүлж байна.

**326.** Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд хүүхдийн уран бүтээл туурвихад төрөөс дэмжлэг үзүүлэх журмыг 2005 онд баталсан ч хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүй байснаас олигтой хэрэгжээгүй явж ирлээ. Иймд Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Сангийн яам хамтран Хүүхдэд зориулсан уран бүтээл туурвихад дэмжлэг үзүүлэх санхүүгийн журмыг шинэчлэхээр ажиллаж байна.

**327.** Монгол Улсад 2006 оны байдлаар урлаг, соёлын 339 байгууллага жилд (давхардсан тоогоор) 4852 удаагийн тоглолт зохион байгуулж, нийт үзэгчдийн 30 гаруй хувийг хүүхэд эзэлдэг гэсэн мэдээ байна.

**328.** Монгол Улсад нийт 290 номын сан ажиллаж байна. Дэлхийн банкны (4.0 сая долларын) буцалтгүй тусламжийн хөрөнгөөр манай улсын 21 аймгийн сум, багийн 383 бага сургуулийн 1–4 дүгээр ангийн хүүхдэд зориулсан иж бүрэн номын сан нийлүүлэх, ангийн номын санд байршуулах номыг сонгох “Хүүхдийн ном худалдан авах” олон улсын тендерийг зарлан шалгарсан 200 нэр төрлийн номыг (тус бүр 3000 хувиар) хэвлүүлэн түгээх ажлыг зохион байгуулж байна. Үүнд хичээлээс гадуур унших болон танин мэдэхүйн чиглэлийн ном багтсан бөгөөд сурагчдын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, номтой нөхөрлөх хөдөлгөөн өрнүүлэх замаар хүүхдийн мэдлэгийн цар хүрээг тэлэхэд оюуны чухал хөрөнгө оруулалт боллоо.

“Хүүхдийн ном худалдан авах” төслөөс дэлхийн хүүхдийн дижитал номын сангийн монгол хэлээр хөрвүүлсэн хувилбарыг бий болгож, түүний албан ёсны нээлтийг 2006 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр хийлээ. Энэхүү номын сан нь хүүхдийн уран зохиолын номыг интернэтээр үнэ төлбөргүй түгээж уншуулах зорилготой юм. Одоогоор монголын болон дэлхийн хүүхдийн шилдэг 15 зохиолыг интернэтэд тавьж, харин интернэтэд холбогдоогүй номын сан, уншигчдад зориулан 2000 ширхэг CD буюу “цахим ном” хэвлүүлэн түгээлээ.

**329.** Хичээлээс гадуурх сургалт хүүхдийн чөлөөт цагийг өнгөрүүлэх нэг хэлбэр болдог. Бага, дунд боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйлд “хичээлээс гадуурх сургалтын ажил суралцагчийн танхимд эзэмшсэн мэдлэг, чадварыг бататгах, баяжуулах, тэдний авьяас, сонирхлыг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд чиглэнэ” гэж заасан бөгөөд хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулдаг юм.

Хичээлээс гадуурх сургалтын ажлын цагийг (1–12 дугаар ангид долоо хоногт тус бүр 1 цаг) ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөөнд оруулж Боловсрол,



соёл, шинжлэх ухааны сайдын тушаалаар баталгаажуулсан бөгөөд хичээлээс гадуурх хичээлийн цагийн ажлын хөлсийг багшид тооцон олгох болсон явдал чөлөөт цаг, хүмүүжлийн ажлын үр дүнг дээшлүүлэх нэг нөхцөл болж байна. Гэхдээ сургуулийн анги, танхим, биеийн тамирын заалыг хүүхдүүд хичээлийн бус цагаар болон амралтын өдрөөр ашиглах бололцоо бага, ашигласан тохиолдолд хүүхдүүд төлбөр төлөх байдал нийтлэг байна.

**330.** Иргэний боловсрол хичээлийн агуулгыг 1–12 ангид танхимын бус цагаар судлахаар болсон юм. Сургуулийн захиргаа хичээлээс гадуурх сургалтын ажлыг дугуйлан, түр сургалт, соёл, урлаг, спортын арга хэмжээ зэрэг хэлбэрээр хичээлийн жилийн турш зохион байгуулдаг. Улсын хэмжээнд нийт сурагчдын 50 гаруй хувь хичээлээс гадуурх дугуйлан, чөлөөт цагийн сургалтад хамрагдаж байгаагаас гадна үндэсний чанартай төрөл бүрийн хичээлийн олимпиад, уралдаан тэмцээнд жил бүр 150 сая төгрөг зарцуулж, эхний байранд шалгарсан хүүхдийг их, дээд сургуульд урилгаар шууд элсүүлэн төрийн зардлаар сургаж байна.

**331.** Улаанбаатар хотод Монголын хүүхдийн ордон, Хүүхдийн урлан бүтээх төв, Залуу зохион бүтээгчдийн ордон болон 10 аймгийн төвд хүүхдийн ордон ажиллаж хүүхэд, залуучуудын чөлөөт цагт зориулсан үйл ажиллагаа явуулж байна. Тухайлбал, 2006/2007 оны хичээлийн жилд Монголын хүүхдийн ордон олон улсын хүүхдийн урлагийн 10 гаруй наадамд 179 хүүхдийг төлөөлөгчөөр оролцуулжээ. Мөн Хүүхдийн урлан бүтээх төв чимэх, чимэглэх урлагийн 10 төрлийн 15 дугуйланд хүүхэд элсүүлж, нийт 512 хүүхдийн урлан бүтээх авьяасыг хөгжүүлсэн мэдээ байна.

**332.** Хүүхдийн зуны амралтыг үр дүнтэй өнгөрөөхөд хүүхдийн зуслан их үүрэгтэй юм. Өнгөрсөн 2006 оны байдлаар хүүхдийн 33 зуслан үйл ажиллагаа явуулж жил дунджаар 40 мянган хүүхэд амарсан байна. Хүүхдийн цөөн зуслан төрийн мэдэлд, үлдсэн нь удирдлагын гэрээгээр, хувийн өмчийн хэлбэрээр ажиллаж байна.

Зусланд хүүхдийг тав тухтай амруулах, хүмүүжил төлөвшлийн зөв хандлага олгох, чийрэгжүүлэхэд чиглэсэн олон талт үйл ажиллагаа явуулах нэгдсэн удирдамж, аргагүйгээр хангахад Зуслангуудын холбоо төрийн бус байгууллага санаачилгатай ажиллаж байна.

Зуслангуудын холбоо бусад талуудтай хамтран хүүхдийн зуслангийн үйл ажиллагааны стандартыг боловсруулж, 2007 оны 7 дугаар сарын 1–нээс орон даяар хэрэгжүүлж эхэлсэн байна. MNS 2006 (03.080.30) стандартын хүрээнд ажилтнуудыг чадваржуулах сургалт явуулах, зуслангийн баазыг бэхжүүлэх, төрийн байгууллагаас дэмжлэг авах чиглэлд илүү анхаарч байна. Олон улсын зуслангуудын холбооны ээлжит хурлыг 2007 оны 9 дүгээр сард монголд анх удаа амжилттай зохион байгууллаа.

Сүүлийн жилүүдэд аялал жуулчлалын журмаар үзэсгэлэнт болон түүх, соёлын дурсгалт газартай танилцах байгалийн аяллын "Хөвсгөл–Байгал"; түүх, шашны аяллын "Мөргөлийн зам"; явган аяллын "Хөдөлгөөн–Эрүүл мэнд"; соёл, түүхийн "Чингисийн өлгий нутгаар" зэрэг улсын чанартай аялал зугаалга, идэвхитэй амралтад хүүхэд, залуучууд өргөн оролцох боллоо. Тухайлбал, Адал явдалт спорт аяллын холбоотой хамтран Залуучуудын явган аялал, Оюутны Туриад аялал (300 хүүхдийн); Хүүхдийн төлөө үндэсний газартай хамтран хөгжлийн бэрхшээлтэй 30 хүүхэд, залууст зориулсан хот

орчмын аялал; Залуучуудын хөгжлийн “Хөх цэрэг” клубтэй хамтран “Эх оронч Монгол хүүхэд” танин мэдэхүйн (700 хүүхдийн) аяллыг зохион байгуулсан байна.

**333.** Мэдээллийн технологийн хөгжлийг даган интернэт кафе, РС тоглоомын газрын тоо эрс олширч, тэнд өсвөр насныхан, ялангуяа хөвгүүд чөлөөт цагаа өнгөрөөх явдал нэмэгдлээ. Тоглоомын газрууд ч орлогоо бодож хүүхдийг олон цагаар тоглуулснаас зарим хүүхэд цахим тоглоомонд донтох байдалд хүрч байна. Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас тоглоомын газрын ажиллах, хүүхдэд үйлчлэх цагийн хуваарийг шинэчиллээ. Гэвч түүний хэрэгжилтэд олон нийтийн зүгээс байнгын хяналт тавих чиг үүрэг хэвээр үлдэж байна.

**334.** Хүүхдийн амралт, чөлөөт цаг, тоглоом наадамд гэр бүл, олон нийтийн зүгээс анхаарч, оршин суугаа гаазртаа хүүхдэд зориулсан чөлөөт цагийн аятай орчин бүрдүүлэх санаачилга өрнөж байна. Хүүхдийн чөлөөт цагийн орчныг бүрдүүлэх ажлыг бодлогоор дэмжиж хот байгуулалтын стандартад тусгах, улмаар түүнийг хүний хүчний болон санхүүгийн нөөцөөр хангах шаардлага нэмэгдэж байна.

**335.** Хүүхдийн тоглоомын үйлдвэрлэл, худалдаалалтын байдалд тавих эрүүл ахуй, ариун цэврийн дүрмийн хэрэгжилтийг холбогдох байгууллагууд тогтмол шалгаж дүнг олон нийт, эцэг эхэд мэдээлж байна. Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас 2007 онд явуулсан шалгалтаар эрүүл ахуй, ариун цэврийн дүрмийн хэрэгжилтийн байдал дахин хангалтгүй дүнтэй гарсан байна. Манай зах зээл ихэвчлэн БНХАУ–д үйлдвэрлэсэн хүүхдийн тоглоомыг худалддаг.

Худалдаанд байгаа хүүхдийн тоглоомоос авсан хүнд металын шинжилгээгээр хар тугалга, цайр, зэсийн агууламж тогтоосон нормативаас 0.0003–25.3 мг/л хүртэл хэмжээгээр их байсныг илрүүлж, түүний тухай сэрэмжлүүлгийг олон нийтэд тархааж байна.

### **Наймдугаар бүлэг. Онцгой хамгааллын арга хэмжээ**

*(22, 30, 32 – 36, 37 дугаар зүйлийн “б” заалт, 39 – 40 дүгээр зүйл)*

**336.** Хүүхдийн онцгой хамгааллын байдлыг үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулсан мэдээллийг Монгол Улсын үндэсний хоёрдугаар илтгэлийн хоёрдугаар бүлэгт буюу 6–7 дахь тал, гуравдугаар бүлэгт буюу 11–15 дахь тал, дөрөвдүгээр бүлэгт буюу 16–19 дахь талд танилцуулсан болно.

**337.** Хүүхдийн эрхийн тухай конвенцийн үзэл санаанд нийцүүлэн Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд 2003 оны 5 дугаар сарын 22–ны өдрийн хуулиар томоохон нэмэлт, өөрчлөлт оруулсан болно. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Хүүхдийг гэмт хэрэг, эрхзүйн зөрчил, хүчирхийлэл, мөрийтэй тоглоом, садар самуун, насанд хүрэгчдийн хоорондын аливаа зөрчил, архи, тамхи, мансууруулах болон хордуулах бодис хэрэглэхэд татан оруулах; доромжлох, басамжлах, гүтгэх, хүчирхийлэх, хулгайлах, барьцаанд авах, худалдах, дамжуулан худалдах, боолчлох буюу түүнтэй адилтгах нөхцөлд байлгах, санаатай солих, хаях, төөрүүлэх; тарчлаан зовоох, тагнуул, хорлон сүйтгэх ажиллагаанд ашиглах, бага насанд нь сүй тавьж албадан гэрлүүлэх; хууль бусаар үрчлэх, хорьж цагдах, гадаадад авч гарах, гадаадаас

оруулж ирэхийг хориглоно” гэж заасан байна.

Мөн хуулийн 7 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хүүхдийг албадан ажиллуулах, ёс суртахуун, эрүүл мэнд, амь насанд нь аюул учруулах хөдөлмөр эрхлүүлэх, хүүхдийн хөдөлмөрийг мөлжлөгийн хэлбэрээр ашиглах, тэдний хөдөлмөрийн хөлсийг шударга бусаар тооцож олгох, гуйлга гуйлгах, хууль бусаар нэрээр нь ашиг олох үйл ажиллагаа явуулахыг хориглох”-оор хуульчилсан байна. Хүүхдийн эрхийг хууль зөрчсөн нөхцөлд захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэж байхаар зохицуулсан байдаг.

**338.** Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлд “байгалийн гамшиг, гоц халдварт өвчин, нийтийг хамарсан гэнэтийн осол, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн хүүхдийг онцгой нөхцөлд байгаа хүүхэд; харин бүтэн өнчин, тахир дутуу, нэн ядуу, хараа хяналтгүй, садар самуун, хүчирхийлэл, доромжлолын улмаас сэтгэл санааны болон бие махбодын хохирол хүлээсэн, эрүүл мэнд, амь насанд нь аюул учруулах хөдөлмөр эрхэлж буй хүүхдийг хүнд нөхцөлд байгаа хүүхэд” гэж тодорхойлсон болно.

Мөн хуульд онцгой нөхцөлд байгаа хүүхдэд яаралтай тусламж үзүүлэх асуудлыг Засгийн газар тухай бүр шийдвэрлэж байхаар заасан бөгөөд хүнд нөхцөлд байгаа хүүхдэд боловсрол, мэргэжил эзэмшихэд туслалцаа үзүүлэх; эрүүл мэндийг нь нөхөн сэргээх, сувилах, тахир дутуу хүүхдэд хиймэл эрхтэн болон бусад хэрэгслийг үнэ төлбөргүй олгох; хүнд нөхцөлд байгаа хүүхдийг үрчилсэн гэр бүлд төрөөс тэтгэмж олгох; хүүхдийг асран хамгаалах байгууллагад шилжүүлж, халамжийн үйлчилгээнд хамруулах; хүүхдийг сайн дурын үндсэн дээр асран хамгаалж байгаа гэр бүлд дэмжлэг үзүүлэх; өвлөх хөрөнгөгүй өнчин хүүхэд төрийн асрамжаас гарахад орон нутгийн засаг захиргаанаас орон байраар хангах халамж, хөнгөлөлт, тусламж үзүүлэхээр заасан байна.

**339.** Монгол Улсад “хүнд нөхцөлд байгаа хүүхэд” гэсэн хуулийн ойлголтод “гэмт хэрэгт өртсөн болон хууль зөрчсөн хүүхэд, үндэстний цөөнхийн эрх нь зөрчигдсэн хүүхэд хамрагдахгүй” байна. Хүнд нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлэх үйлчилгээний тогтолцоо зүгшрээгүй, хүүхдийн асуудал хариуцсан байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа хангалтгүй байгаа талаар нийгмийн хамгааллын хэсэгт танилцуулсан болно.

Хүүхэд хамгааллын тогтолцооны урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг хөгжүүлэх, хүн амын нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын хүүхдийн хамгааллын асуудлаар хэрэгжүүлэх чиг үүргийг нарийвчлан тодорхойлох, түүний үйл ажиллагаанд шинэ арга барил нэвтрүүлэх шаардлагатай байна.

#### **А. Онцгой хүнд нөхцөл байдалд буй хүүхэд**

**340.** Хүүхдийн эрхийн хорооноос хүүхдийн тусгай хамгааллын эрхийн чиглэлээр Монгол Улсад өгсөн дүгнэлт, зөвлөмжийн 57 дугаар зүйлийн дагуу Дүрвэгчийн эрх дархын тухай 1951 оны конвенц, түүний 1967 оны нэмэлт протоколыг хүлээн зөвшөөрөх асуудлыг судалж байна.

**341.** Монгол Улсад зэвсэгт мөргөлдөөнд оролцож байгаа хүүхэд байхгүй бөгөөд дүрвэгч хүүхдийн талаар мэдээлэл алга байна.

**342.** Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай, Дайны тухай, Дайн бүхий байдлын

тухай хуульд хүүхдийн тусгай хамгааллын арга хэмжээний талаар тусгайлан заасан заалт одоогоор байхгүй байна.

**343.** Байгалийн гамшиг, гоц халдварт өвчин, нийтийг хамарсан гэнэтийн осолд өртсөн хүүхдэд анхны тусламж, дэмжлэг үзүүлэх үүргийг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүлээж байна. Гамшигийн голомтод байгаа хүүхдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх асуудлыг Засгийн газрын шийдвэрийн дагуу онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцан зохион байгуулж байна.

**344.** Сүүлийн жилүүдэд алт, жонш, нүүрс зэрэг ашигт малтмалыг гар аргаар олборлогчдын тоо эрс өсөж, орд газрыг бараадан нүүдэллэн амьдрагч иргэдийн хэдэн зуун хүнтэй түр суурин газар орон нутагт үүсэх боллоо. Хууль бусаар тухайн нутагт оршин сууж гар аргаар ашигт малтмал олборлож байгаа иргэд, түүний хүүхэд, гэр бүлийн гишүүд нийгмийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, улмаар гэмт хэрэг, осол гэмтэлд өртөх өндөр эрсдэлтэй нөхцөлд амьдарч байна. Зарим хүүхэд тэвчишгүй хүнд хөдөлмөрт татагдан орох, химийн бодисонд хордох, ахуйн болон үйлдвэрлэлийн осолд орох, сургууль завсардах зэрэг эрсдэлд өртөж байна.

Байгалийн баялгийг олборлох үйл ажиллагаанд тавих хяналт суларч, хуулийг гажуудуулснаас хэд хэдэн газар нутагт хүнд нөхцөл байдал үүссэн байна. Тухайлбал, Дархан–Уул аймгийн Хонгор суман дахь Хятад, Монголын хамтарсан алтны хувийн үйлдвэр алт ялгах ажилд ашигласан цианит натрийг саармагжуулалгүй сумын төвийн орчимд ил задгай хаяснаас тодорхой тооны хүн, мал, амьтад хордсоноос эмнэлгийн нарийн мэргэжлийн дэмжлэг, туслалцаа шаардагдаж байна.

Манай орны зарим нутагт зун, намрын цагаар байгалийн голомтот гоц халдварт тарваган тахал зэрэг өвчин гарах, дэгдэх магадлал өндөр байдаг. Хөвсгөл, Говь–Сүмбэр зэрэг аймагт 2007 онд 17–18 насны цөөн хүмүүс тарваган тахал өвчнөөр өвчилсөн болох нь тогтоогдсон учир хөл хорио цээрийн дэглэмийн дагуу тэдэнд эмнэлгийн мэргэжлийн болон онцгой байдлын яаралтай тусламж үзүүлсэн байна.

**345.** Байгалийн аюулт үзэгдэл болон техникийн холбогдолтой осол зэрэг ажиллагаанд хүүхэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, аврах, аюулгүй байдлыг хангах, яаралтай тусламж үзүүлэх шуурхай ажиллагааны төлөвлөгөө, зохицуулах журам, заавар тодорхойгүй байна. Энэ чиглэлээр Хүүхдийн төлөө үндэсний газар, Онцгой байдлын ерөнхий газартай 2006 онд хамтын ажиллагааны гэрээг байгуулсан бөгөөд гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах чиглэлээр хүүхэд, өсвөр үеийнхний дунд сургалт, сурталчилгааг хамтран зохион байгуулах ажлыг эхэллээ.

Японы Засгийн газраас НҮБ–ын Хүүхдийн сангаар дамжуулан санхүүжүүлж буй Шулууны томуунаас сэргийлэх сургалт, сурталчилгааны (1040.0 мянган ам.долларын өртөг бүхий) төслийг 2006 оноос Онцгой байдлын ерөнхий газар, Эрүүл мэндийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам хамтран хэрэгжүүлж байна.

**346.** Тайлангийн хугацаанд халдварт өвчин дэгдэх, техникийн осол гарах, нийтийг хамарсан хөдөлгөөн, тэмцэл (онгоцны осол, хадгаламж, зээлийн хоршоодын дампуурлаас үүдэлтэй олон хүн өлсгөлөн зарлах зэрэг) өрнөсөн нөхцөлд хүүхдийг хамгаалах асуудал хурцаар тавигдлаа. Үүнээс болоод хүүхэд, багачууд сургуулиас

хөндийрөх, эрүүл мэндээр хохирох, сэтгэл санааны хямралд орох, өнчрөх зэрэг тохиолдолд халамж, хамгааллын яаралтай арга хэмжээ авах, үйлчилгээ үзүүлэх хэрэгтэй болсон юм.

Тухайн цаг үеийн нөхцөл байдалд тохируулан эрүүл ахуй, ариун цэвэр, халваргүйжүүлэлтийн дэглэмийг сурталчлах, чанд сахиулах, өлсгөлөн тэмцлийн ажиллагаанд хүүхэдтэйгээ оролцохыг хориглох, улмаар таслан зогсоох, бага насны хүүхдийг тодорхой цагаар асрах, өнчирсэн хүүхдэд нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж ажиллалаа. Гэвч энэ ажилд арга, туршлага дутах, мэдээллийн сан бүрдүүлэлгүй орших явдал гарлаа.

### **Б. Хууль зөрчсөн хүүхдүүд**

**347.** Хууль зөрчсөн хүүхдийн нас, хууль зөрчсөн эсэхийг тогтоох үндэслэл, байцаан шийтгэх үйл ажиллагааны талаар Монгол Улсын хоёрдугаар илтгэлд танилцуулсан болно.

**348.** Тайлант хугацаанд насанд хүрээгүй хүмүүсээс 2004 онд нийт 1034 гэмт хэрэгт 1548 хүүхэд, 2005 онд 891 гэмт хэрэгт 1332 хүүхэд, 2006 онд 1049 гэмт хэрэгт 1555 хүүхэд, 2007 оны эхний 8 сарын байдлаар 658 гэмт хэрэгт 962 хүүхэд тус тус гэмт хэргийн холбогдогчоор бүртгэгдэн шалгагдсан байна. Тайлангаас үзэхэд насанд хүрээгүй хүмүүс ихэнхдээ хулгай хийх, танхайрах, дээрэмдэх, бусдын эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийг зонхилон үйлдсэн байна.

**349.** Хууль зүй, дотоод хэргийн яам холбогдох байгууллагатай хамтран “Хүүхэд гэмт хэрэгт холбогдож байгаа шалтгаан нөхцөл”-ийн судалгааг 2004 онд, “Хүүхдэд хүлээлгэж буй эрүүгийн хариуцлага”-ын судалгааг 2005 онд явуулсан бөгөөд эдгээр судалгааны явцад хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааг эрчимжүүлэх, гэмт хэрэгт холбогдсон хүүхдэд байцаан шийтгэх ажиллагаа явуулах тусгай журам гаргах, хүүхдийн асуудлаар дагнан ажилладаг мэргэшсэн мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нарыг бэлтгэх шаардлага, хэрэгцээ байгааг тодорхойлсон байна. Үүний үндсэн дээр Хууль зүй, дотоод хэргийн яам аймаг, нийслэлийн ерөнхий шүүгч, прокурор болон цагдаагийн газар, хэлтсийн дарга нарт хандан насанд хүрээгүй хүмүүстэй холбоотой хэргийг дагнан хариуцах, *өөрөөр хэлбэл* мэргэшүүлж байгаа ажилтнууддаа хуваарилан шийдвэрлүүлж байх зөвлөмжийг 2006 оноос хойш хэрэгжүүлж байна.

Түүнчлэн хууль эрх зүйн мэргэжлийн дээд боловсрол эзэмшүүлэх сургуулийн бакалаврын шатны сургалтын хөтөлбөрт хүүхдийн эрх, хамгааллын асуудлыг шинээр оруулсан байна.

**350.** Хүүхдийн эрхийн хорооноос насанд хүрээгүй хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлээр Монгол Улсад өгсөн дүгнэлт, зөвлөмжийн 68 дугаар зүйлд заасан хүүхдэд ногдуулж байгаа ялын бодлогыг шинэчлэх, цагдан хорих хугацааг богиносгох үүднээс Засгийн газар Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2007.08.09) хуулийг санаачлан боловсруулж, түүнийг УИХ-аар батлуулан хэрэгжүүлж байна. Энэхүү хуульд насанд хүрээгүй хүнд шүүхээс хорих ял ногдуулахдаа Эрүүгийн хуулийн тусгай ангид тухайн гэмт хэрэгт ногдуулахаар заасан хорих ялын доод хэмжээний хоёрны нэгээс хэтрэхгүй, хүүхдийг хорьж мөрдөх хугацааг 8 сараас хэтрэхгүй байхаар заасан байна. Хулгай, булаалтын гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээх доод

талын нас 14 байсныг өөрчлөн зөвхөн хөнгөн хэлбэрийн хулгай, булаалтын гэмт хэрэгт эрүүгийн хариуцлагад татах доод талын насыг 16 нас болгосон байна.

*Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зарим зүйл, заалтыг тодруулбал:*

- (1) Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд дараах сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны ажиллагаанд өмгөөлөгчийг заавал оролцуулахаар заасан байна:
  - хэлгүй, дүлий, хараагүй зэрэг эрхтэн дутуу буюу сэтгэцийн өвчний улмаас өөрийгөө өмгөөлөх болон өмгөөлүүлэх эрхээ эдэлж чадахгүй;
  - насанд хүрээгүй;
  - монгол хэл, бичиг мэддэггүй;
  - цаазаар авах ялаар шийтгэгдэж болох;
  - хэргийнхээ талаар харилцан эсрэг сонирхолтой сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн аль нэг нь өмгөөлөгчтэй байгаа бол бусад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч;
  - төлбөрийн чадваргүй этгээд өмгөөлөгч оролцуулах хүсэлт гаргасан бол;<sup>15</sup>
- (2) Гомдлыг хүлээн авсан хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албаны дарга, прокурор 14 хоногийн дотор, нэмэлт материал шалгах буюу бусад арга хэмжээ авах бол ажлын 21 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ.
- (3) Насанд хүрээгүй гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагчийн өмгөөлөгч хүсэлт гаргасан тохиолдолд өөрийн зардлаар байцаалтын явцыг дүрс бичлэгээр бэхжүүлэн авч болох бөгөөд энэ тухай хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын тэмдэглэлд тусган, дүрс бичлэгийг хэрэгт хавсаргана.”<sup>16</sup>
- (4) Насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, гэрч, хохирогч буюу 18 насанд хүрээгүй этгээд хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, тэдгээрийн сэтгэл зүйн онцлогийг харгалзан байцаалтын явцыг дүрс бичлэгээр бэхжүүлэх талаар өмгөөлөгч өөрийн зардлаар явуулах хүсэлт гаргавал хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор хүсэлтийг хангана.
- (5) Насанд хүрээгүй гэрч, хохирогчийг байцаахын өмнө түүнд хэргийн талаар мэдэх бүх зүйлээ үнэн зөв мэдүүлэхийн чухлыг тайлбарлан өгөх бөгөөд харин 16 насанд хүрээгүй гэрч, хохирогчид мэдүүлэг өгөхөөс татгалзах буюу зайлсхийх, санаатайгаар худал мэдүүлэг өгвөл хүлээлгэх хариуцлагын талаар урьдчилан сануулахыг хориглоно.
- (6) Эрүүгийн хуульд гэмт хэргийн субъект нь 16 наснаас эхлэх бөгөөд насанд хүрээгүй этгээд гэдгийг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, түүнчлэн Хүүхдийн эрхийн тухай хуульд заасантай нийцүүлсэн байна. Энэ нь 16 насанд хүрсэн гэрч, хохирогчид Эрүүгийн хуулийн тусгай ангийн 254, 255 дугаар зүйлийг сануулан байцаалт авахаар тусгасан байна.

<sup>15</sup> Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт

<sup>16</sup> Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн хуулийн 370 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

**351.** Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг таслан зогсоох, шаардлагатай арга хэмжээг авах, мөрдөн байцаах, хэрэг үйлдсэн, гэмт хэргийн хохирогч болсон эсэхийг тогтоох чиг үүргийг тухайн шатны Засаг дарга, цагдаагийн байгууллага хүлээх боловч буруутай эсэхийг зөвхөн шүүх тогтооно. Хорих болон баривчлах ялыг шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллага гүйцэтгэх бөгөөд нөхөн сэргээх, дахин нийгэмшүүлэх үйлчилгээг тухайн шатны Засаг дарга, нийгмийн хамгаалал, халамжийн байгууллагууд хариуцахаар хуульчилсан байна.

**352.** Хууль зүй, дотоод хэргийн яам, НҮБ-ын Хүүхдийн сан хамтран “Насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх хороо”-г загвар байдлаар Хэнтий аймаг, нийслэлийн Баянгол, Багануур дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэд байгуулан түүнд нарийн бичгийн даргыг орон тоогоор ажиллуулж байна. Энэ загвар хороод шүүхээс өмнөх шатанд хүүхдийг дааж хариуцах, байцаан шийтгэх үйл ажиллагааны явцад хүүхдийн хэргийг шийдвэрлэхэд оролцох, санал дүгнэлт гаргаж өгөх, хүүхдийг батлан даалтад авах, улмаар хүүхдийг орон нутагт нь сурган хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх, олон нийтэд түшиглэсэн хөтөлбөрт хамруулах зэрэг ажлыг зохион байгуулж байна.

**353.** НҮБ-ын Хүүхдийн сан, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр насанд хүрээгүй хүмүүсийг эрүү шүүлт, харгис хүнлэг бус байдлаас ангид байлгах зорилгоор хүүхдээс мэдүүлэг авах өрөөг цагдаа, шүүхийн байгууллагад шинээр байгуулж, үр дүнтэй ажиллуулж байна.

Цагдаагийн байгууллагад байгуулсан хүүхдийн өрөөг мэдүүлэг авахаас гадна хүүхдийг гэмт хэргээс сэргийлэх сурталчилгаа явуулах, хараа хяналтгүй хүүхдийг түр байрлуулах, хэрэг үйлдсэн хүүхдийг хохирогчтой эвлэрүүлэх, сэжигтнийг хүүхдээр таньж олуулах, мөн гэмт хэрэг үйлдэх үедээ 18 насанд хүрээгүй байсан иргэнийг сэжигтэн, яллагдагчаар, насанд хүрээгүй этгээдийг гэрч, хохирогчоор гагцхүү хүүхдийн өрөөнд байцааж мэдүүлэг авах зэргээр ашиглаж байна.

Түүнчлэн хүүхдийн өрөөний ашиглалтад эрх бүхий албан тушаалтан хяналт тавих журмыг боловсрууллаа. Шүүхэд байгуулсан хүүхдийн тусгай өрөөнд хүүхдийн хэргийг тусгайлан хариуцах шүүгчийг ажиллуулах, тусгай өрөөний зориулалтыг өргөжүүлэн хүүхдэд тохирсон аргаар хэргийг хянан шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх чиглэлд анхаарч ажиллаж байна.

**354.** Насанд хүрээгүй хүмүүст хууль зүйн зохих тусламж үзүүлэх, өмгөөллийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах шаардлага тулгарч байна. Монголын өмгөөлөгчдийн холбоо, Нийслэлийн өмгөөлөгчдийн холбоо хамтран “Насанд хүрээгүй иргэдийн өмгөөллийн эрх зүйн орчныг сайжруулах өмгөөлөгчдийн хороо” байгуулан ажиллаж байна. Хөдөө орон нутагт өмгөөлөгчийн хүрэлцээ хангалтгүй, хүүхдийн асуудлаар мэргэшсэн өмгөөлөгч ховор, насанд хүрээгүй хүмүүсийн өмгөөллийн үйлчилгээний төлбөр тэдний өмгөөллийн үйлчилгээ авах боломжийг хязгаарлахад нөлөөлж байна.

Насанд хүрээгүй хүмүүсийн өмгөөллийн зардлыг Засгийн газраас тусгайлан төлөвлөдөггүй бөгөөд төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөллийн зардалд зориулан жил бүр улсын төсвөөс зохих хэмжээний хөрөнгийг Монголын өмгөөлөгчдийн холбоонд олгож байсныг өөрчилж, төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөллийн зардлыг Хууль

зүй, дотоод хэргийн сайдын багцад оруулан тусгах болсноор Монголын өмгөөлөгчдийн холбоо насанд хүрээгүй хүмүүсийн өмгөөллийн зардлыг олж авахад ихээхэн бэрхшээл учрах болсон байна.

**355.** Харин Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан насанд хүрээгүй хүмүүст үзүүлэх өмгөөллийн үйлчилгээг улам өргөжүүлэх, хөгжүүлэх боломж нээгдэж байна гэж Монголын өмгөөлөгчдийн холбоо үзэж, хүүхдийн эрхийг хамгаалах өмгөөлөгчийг дадлагажуулах, мэргэшүүлэх ажлыг эрчимжүүлэх хүсэл сонирхолтой байна.

**356.** Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 37 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хэргийг байцаан шийтгэх ажиллагаанд тэдгээрийн хууль ёсны төлөөлөгчийг оролцуулах, мөн хуулийн 40 дүгээр зүйлд насанд хүрээгүй хүүхдийн хэрэг бүртгэл, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны ажиллагаанд өмгөөлөгчийг заавал оролцуулахаар заасан хэдий ч амьдралд бодитой хэрэгжихгүй байна.

**357.** Хууль зөрчсөн хүүхдийн эрх зөрчигдөхөд эдүгээ үйлчилж байгаа эрх зүйн тогтолцоо, шүүхийн байгууллагын ажилтан нарын ажлын ур чадвар, сэтгэлгээний хандлага, хүүхдийн гэр бүлийн орчин зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байна.

#### **Эрх чөлөөгөө хасуулсан хүүхэд**

**358.** Хүүхдийг цагдан хорих үйл ажиллагааны орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын харьяа насанд хүрээгүйчүүдийн цагдан хорих байрыг нэлээд сайн тохижуулсан байна. Харин орон нутгийн цагдан хорих байрны нөхцөл хүүхдэд тохирохгүй хэвээр байна.

**359.** Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын харьяа насанд хүрээгүйчүүдийг хорих нэг анги ажилладаг бөгөөд түүнд зөвхөн эрэгтэй хүүхдийг хүлээн авдаг. Харин охидыг эмэгтэйчүүдийн хорих ангийн тусгай хэсэгт хүлээн авдаг. Эдгээр газарт 2004–2006 онд нийт 356 хүүхэд хорих ял эдэлсний 16 нь охид байлаа.

Хүүхдэд шүүхээс ногдуулсан хорих ялын дундаж хугацаа 2–5 жил байсан бөгөөд Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг тохиолдуулан насанд хүрээгүй хүмүүст төрөөс 2006 оны 7 дугаар сард өршөөл, уучлал үзүүлж, эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн байна.

**360.** Ганц худгийн хорих ангид ял эдэлж байгаа насанд хүрээгүй хүмүүсийн 60 хувь, гэмт хэрэг үйлдсэн хүүхдийн 70 орчим хувь нь өөрсдийнхөө эрх, үүргийн талаар мэдлэг хангалтгүйгээс өмгөөлөгчийн тусламж аваагүй байна. Тэдний ихэнх нь бага орлоготой өрхийн аль эсвэл бүтэн ба хагас өнчин хүүхдүүд байна<sup>17</sup>. Гэмт хэрэг үйлдсэн хүүхдийг цаазаар авах, ялангуяа хүүхдэд ялын дээд хэмжээ болон насаар хорих ял ногдуулахыг хориглох

**361.** Хууль зөрчсөн хүүхдэд ял ногдуулах үйл ажиллагааны талаар Монгол Улсын хоёрдугаар илтгэлд танилцуулсан болно. Бие бялдар, сэтгэл зүйн хувьд нөхөн сэргээх, нийгмийн амьдралд буцаан оруулах

**362.** Өнгөрсөн хугацаанд гэмт хэрэгт холбогдсон хүүхэдтэй ажиллдаг хууль сахиулах байгууллагын ажилтанд зориулсан гарын авлага, хэрэглэгдэхүүнийг боловсруулж

<sup>17</sup> Монгол Улсын хүүхэд, эмэгтэйчүүдийн байдал, НҮБ-ын Хүүхдийн сан, 2007



хүргүүлсний зэрэгцээ “Хүүхдийн эрүүл мэнд ба урьдчилан сэргийлэх үйлчилгээ”, “Бэлгийн замаар дамжин халдварлах хам шинжийн оношилгоо, эмчилгээ”, “Холимог бүлгийн сургалт” зэрэг сэдвээр сургалт, семинарыг төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулсан байна.

**363.** Ял эдэлж байгаа болон хорихоос суллагдсан хүүхдийг нийгэмшүүлэх туршилтын үйлчилгээг явуулж байна. Тухайлбал, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллага санаачлан Хүүхдийн хорих ангид “Нээлттэй хэсэг” байгуулж, нийгэмшүүлэх үйлчилгээний албыг ажиллуулж байна. Энэ алба нь 2002 оноос хойш хугацаанд нийт 72 хүүхдийг хорих ангиас суллагдахын өмнө нээлттэй хэсэгт байршуулан боловсролын үйлчилгээнд хамруулах, мэргэжлийн баримжаа олгох зэргээр дэмжлэг үзүүлсэн байна. Нээлттэй хэсгээр дамжин гарсан 72 хүүхэд дахин гэмт хэрэгт холбогдоогүй байна.

**364.** Хорихоос суллагдсан, хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн, гадуур мөрдөгдөж байгаа, гэмт хэрэг зөрчилд орох эрсдэлд хүрсэн хүүхэдтэй ихэвчлэн цагдаагийн байгууллага болон зарим нэг төрийн бус байгууллага ажилладаг учраас тэдний эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал, халамж, тэтгэлэг, засаг захиргааны харъяаллын асуудал зэргийг цогцоор шийдвэрлэж чадахгүй байна. Мөн гэмт хэргийн хохирогч болсон хүүхдийг хамгаалах, тэдэнд үзүүлэх нөхөн сэргээх үйлчилгээ хөгжөөгүй байна.

## **В. Мөлжлөгт өртсөн хүүхэд**

### **Эдийн засгийн мөлжлөг: хүүхдийн хөдөлмөр**

**365.** Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн дүгнэлт, зөвлөмжийн 61 дүгээр заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 138, 182 дугаар конвенцийг таниулах, сурталчлах үйл ажиллагааг явуулж байна.

**366.** Монгол Улсын хоёрдугаар тайланд дурдагдаагүй зарим зүйлийг тайлбарлаж байна. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2–т “иргэн аж ахуйн нэгж, хүүхдийг албадан ажиллуулах, ёс суртахуун, эрүүл мэнд, амь насанд нь аюул учруулах хөдөлмөр эрхлүүлэх, хүүхдийн хөдөлмөрийг мөлжлөгийн хэлбэрээр ашиглах, тэдний хөдөлмөрийг шудрага бусаар тооцон олгох, гуйлга гуйлгах, хууль бус нэрээр ашиг олохыг хориглосон” байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 109, 110 дугаар зүйлд насанд хүрээгүй хүний хөдөлмөрийн ба эрүүл мэндийг хамгаалах харилцааг дараах байдлаар зохицуулсан байдаг.

#### *Тухайлбал,*

- 16 насанд хүрсэн хүн хөдөлмөрийн гэрээ байгуулах эрхтэй.
- Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг хөдөлмөрийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батлана. Арван таван насанд хүрсэн хүн эцэг, эх буюу харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр энэхүү жагсаалтаар хориглоогүй хөдөлмөрийг эрхэлж, эцэг, эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлтэйгээр хөдөлмөрийн гэрээ байгуулж болно.
- Мэргэжлийн баримжаа, ажлын дадлага олгох зорилгоор 14 насанд хүрсэн хүнтэй эцэг эх, асран хамгаалагч болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгээр хөдөлмөрийн гэрээ байгуулж болно.

- Насанд хүрээгүй хүнийг эмнэлгийн үзлэгт орсны дараа ажилд авах бөгөөд
- түүнийг 18 насанд хүртэл нь хагас жил тутам эмнэлгийн үзлэгт хамруулна.
- Насанд хүрээгүй ажилтныг шөнийн буюу илүү цагаар, түүнчлэн нийтээр амрах баярын болон долоо хоногийн амралтын өдөр ажиллуулахыг хориглоно.
- Насанд хүрээгүй ажилтныг хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлтэй ажилд ажиллуулахыг хориглоно.
- Хөдөлмөрийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний баталсан хэмжээнээс илүү хүнд ачааг насанд хүрээгүй ажилтнаар өргүүлэх, зөөлгөхийг хориглоно.
- Эмэгтэй болон насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажил гүйцэтгүүлсэн, зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү хүнд ачааг өргүүлсэн, зөөлгөсөн, насанд хүрээгүй хүнийг хэвийн бус нөхцөлтэй, түүний оюун ухааны хөгжил, эрүүл мэндэд нь харшлах ажлын байранд, эсвэл амралтын өдөр, шөнө буюу илүү цагаар ажиллуулсан ажилтныг Хөдөлмөрийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн заалтыг зөрчиж илүү цагаар ажиллуулсан албан тушаалтныг 15000–30000 төгрөгөөр хөдөлмөрийн улсын байцаагч буюу шүүгч торгох зэрэг болно.

**367.** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай (2002 оны) хуульд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас эмзэг бүлгийн хүүхдүүдэд мэргэжил эзэмшихэд нь хөнгөлөлт, тэтгэлэг үзүүлэхээр заасан байна. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хүүхдийг хүчээр болон албадан хөдөлмөрлүүлсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр торгох буюу дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэхээр заасан байна.

**368.** Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны дэргэд 2000 онд байгуулагдсан Хүүхдийн хөдөлмөрийн асуудлаарх үндэсний зохицуулах хорооны бүрэлдэхүүнийг 2006 онд шинэчилсэн байна. Энэхүү хороо нь ОУХБ–ын Хүүхдийн хөдөлмөрийг устгах төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг хууль тогтоомж, бодлого шийдвэрт тусгах, түүний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.

“Монгол Улс дахь хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх” хөтөлбөрийн (2002–2005 он) хоёр дахь шатны хэрэгжилтийн явцад дараах үр дүн гарсан байна:

- Хүүхдийн хөдөлмөрийн сөрөг нөлөөний талаар олон нийтийн ойлголт дээшлүүлэх сургалт, сурталчилгааг өргөжүүлэн ажиллаж байна.
- Хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар төрийн байгууллагын ажилтнуудад зориулсан “Хүүхдийн хөдөлмөр–Таны бүрэн эрх” гарын авлагыг боловсруулж, хоёр үе шаттай сургалтыг үндэсний хэмжээнд явуулж, түүнд 700 гаруй хүнийг хамруулав.
- Сургууль завсардан хөдөлмөр эрхэлж байсан 2994 хүүхдийг албан бус сургалтад хамруулан төв, орон нутгийн байгууллагуудтай хамтран ажилласны дүнд 1593 хүүхэд ердийн сургуульд шилжиж, 587 хүүхэд мэргэжлийн сургалтад суралцсан байна.
- Хүүхдийг тэвчишгүй хүнд хөдөлмөрөөс хөндийрүүлэхийн тулд 281 гэр бүлийг орлого нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрт хамруулж, амьжиргаагааг нь дэмжсэн байна.

- Олон улсын худалдааны “Нарантуул” зах дээр хөдөлмөр эрхлэгч хүүхдэд зориулан мэдээлэл, хөгжлийн өрөө ажиллуулж, хүүхдүүд амрах, зурагт үзэх, сонин унших, дулаацах, бусадтай мэдээлэл солилцох боломжоор хангаж, улмаар хүүхэд, гэр бүлд зөвлөгөө өгөх, нийгмийн үйлчилгээ үзүүлэх, сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий нийгмийн ажилтан нарыг ажиллуулж, 250 шахам хүүхдэд мэргэжлийн үйлчилгээ үзүүллээ. “Нарантуул” захад 2007 оны байдлаар хөдөлмөр эрхэлдэг 450 хүүхэд (давхардсан тоогоор) бүртгүүлснээс 180 хүүхдийг эмнэлгийн үйлчилгээнд хамруулж, 28 хүүхдийг дунд сургуульд оруулан 3 дүүргийн албан бус боловсролын сургалтад 36 хүүхдийг хамруулсан байна.
- Хүүхдийн хөдөлмөрийн талаар олон нийтийн ойлголт дээшилж, төрийн байгууллага, ажил олгогч эздийн болон үйлдвэрчний байгууллагын ур чадвар нэмэгдсэн байна.
- Сургууль завсардаж хөдөлмөр эрхэлж буй хүүхэд албан бус боловсролд хамрагдах боломжийг нэмэгдүүлсэн, хүүхдэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд олон хүүхдийн амьдралд эерэг өөрчлөлт гаргаж чадсан байна.
- Үндэсний хөтөлбөрийн хүрээнд Монголын улаан загалмайн нийгэмлэг АЙПЕК хөтөлбөртэй хамтран хүүхдийг хог түүх хөдөлмөрөөс хөндийрүүлэх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн төслийг 2001–2002 онд Баянзүрх дүүргийн, 2003–2005 онд Сонгинохайрхан дүүргийн хатуу хог, хаягдлын задгай цэг дээр хэрэгжүүллээ.
- Нийслэлийн Улаан загалмайн хорооноос эрхлэн хийсэн хогийн цэг дэх хүүхдүүдийн хэрэгцээг тодорхойлох дүн шинжилгээний явцад хогийн цэгт ажил эрхэлдэг 8–17 насны 130 хүүхэд бүртгэгдсэн нь тэнд байнга ажилладаг хүмүүсийн 40 хувийг эзэлж байна.

**369.** Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр (АЙПЕК)– гурав дахь удаагийн хөтөлбөр, төслийг 2005–2009 он хүртэл хэрэгжүүлж байна. Энэ хөтөлбөр, төслийн хүрээнд албан бус уурхай, хөдөө аж ахуй болон үйлчилгээний салбарт хөдөлмөр эрхэлж байгаа, түүнчлэн айл гэрт болон амралт цэнгээний газар үйлчлэгчээр ажиллах зэргээр тэвчишгүй хөдөлмөрт татагдах эрсдэлтэй 6000 гаруй хүүхдэд чиглэсэн цогц үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлээд байна.

Энэ хүрээнд хүүхэд бүрт боловсрол, нийгмийн үйлчилгээг шууд үзүүлэх замаар тэднийг хүнд хөдөлмөрөөс хөндийрүүлэх, урьдчилан сэргийлэхээр ажиллаж байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн хөдөлмөрийн асуудал тулгамдсан Улаанбаатар хот, Өвөрхангай, Төв, Баянхонгор, Дорноговь, Дорнод аймгийн засаг захиргаа илүү санаачилгатай ажиллах шаардлагатай байна.

**370.** Хүүхдийн эрхийн хорооны дүгнэлт, зөвлөмжийн 61 дүгээр заалтыг хангах чиглэлээр Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлөөс Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хүнд хэлбэрийг устгахад чиглэсэн нөлөөллийн стратегийг 2007 онд батлан хэрэгжүүлж эхэлсэн явдал чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байна. Энэхүү стратегийн хүрээнд бодлого боловсруулагч, олон нийт болон хэвлэл мэдээллийн ажилтан, хүүхдэд чиглэсэн нөлөөллийн олон талт үйл ажиллагаа явуулах, хүүхдийн хөдөлмөрийн талаарх хууль

тогтоомж, бодлогын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах, хүүхдийг тэвчишгүй хүнд хөдөлмөрөөс хөндийрүүлэх хөтөлбөр, төслийг өргөжүүлэх замаар олон нийтийн хандлагад өөрчлөлт гаргахыг зорьж ажиллаж байна.

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хүнд хэлбэрийг устгахад чиглэсэн нөлөөллийн стратегийн хэрэгжилтийг Хүүхдийн төлөө үндэсний газар, орон нутгийн хүүхдийн төлөө төвүүд хянах үүрэгтэйгээр ажиллаж байна.

**371.** Монгол Улсын Засгийн газар Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын ажил олгогч эздийн холбоо уул уурхайн салбарт хүүхдийн хөдөлмөрийг 2015 он гэхэд арилгах талаар хамтран ажиллах гурван талт хэлэлцээрийг 2005 онд байгуулан ажиллаж байна. Энэ хэлэлцээрийн дагуу орон нутагт ухуулга сурталчилгааны ажил өрнүүлэх, мэргэжлийн боловсрол олгох зэргээр хүүхдийг уурхайн хөдөлмөрөөс хөндийрүүлэх ажлыг Монголын ажил олгогч эздийн холбооноос эрхлэн 2006 оноос талуудын оролцоотойгоор эхлээд байна.

**372.** Хүүхдийн төлөө үндэсний газар “Хөдөө аж ахуй дахь хүүхдийн хөдөлмөрт анхаарал хандуулъя” зөвлөлдөх уулзалтыг (2007 оны 6 дугаар сарын 12–ны өдөр) зохион байгуулсан байна. Энэхүү уулзалтын явцад Хүнс, хөдөө аж ахуйн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам хамтран Хөдөө аж ахуйн салбарт хүүхдийн хөдөлмөрийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх уриалга гаргаж, хамтын ажиллагааны гэрээний төслийг баталсан байна. Орон нутагт хөдөө аж ахуйн салбарт тэвчишгүй хүнд хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийг хамгаалах, тэднийг боловсрол, нийгмийн үйлчилгээнд хамруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгаврын хамт аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлж, түүнийг төв, орон нутагт хэрэгжүүлж эхэллээ.

**373.** Хүүхэд, өсвөр үеийнхэн эрүүл мэнд, аюулгүй байдал, хөгжилдөө сөрөг нөлөө үзүүлэх орчин нөхцөлд хүнд тэвчишгүй хөдөлмөр эрхэлж байгааг Олон улсын хөдөлмөрийн байгууллага, НҮБ–ын Хүүхдийн сан, Их Британий Хүүхдийг ивээх сангийн хийсэн судалгааны дүн нотолж байна. Хүүхэд гэрийн үйлчлэгч<sup>18</sup> хийх, айлд хөлсөөр мал маллах<sup>19</sup>, зах дээр жижиг наймаа эрхлэх, гуйланчлах<sup>20</sup>, ил, далд уурхайд ажиллах<sup>21</sup> зэрэг бусад хэлбэрийн<sup>22</sup> албан бус хөдөлмөрийг эрхэлсээр байна.

**374.** Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчдыг мэргэжүүлэх, чадваржуулах замаар хүүхдийн хөдөлмөрийн байдалд тавих хяналтыг сайжруулахад анхаарч Хөдөлмөрийн байцаагчдын үйл ажиллагааны гарын авлагыг 2006 онд хэвлүүлж тараасан байна. Хөдөлмөрийн болон нийгмийн халамжийн байцаагч, ажил олгогчдын төлөөллийг оролцуулсан сургалтыг 2006 оны 9 дүгээр сард зохион байгуулж, хүүхдийн хөдөлмөрийн талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд хөдөлмөрийн байцаагчдын зүгээс баримтлах

<sup>18</sup> Улаанбаатар хотын зургаан дүүрэгт 6148 хүүхэд гэрийн үйлчлэгчээр ажиллаж байна.

<sup>19</sup> 2001 онд 255 малчин өрхийг хамруулан судалгаа хийхэд мал маллаж байгаа хүүхдийн тэн хагас нь насанд хүрэгчидтэй адил хөдөлмөр хийж, бага хөлс авдаг байна.

<sup>20</sup> 2002 онд хийсэн судалгаагаар Улаанбаатар хотын захуудад 300 гаруй хүүхэд хөдөлмөр эрхэлж байв.

<sup>21</sup> 2002 онд хийсэн энэ чиглэлийн судалгаанд уурхайд байнга ажилладаг 1871 хүүхэд хамрагдсан байна. Тэд алтыг цэвэрлэхдээ мөнгөн ус, цианит натрийг ашиглаж байжээ.

<sup>22</sup> Насанд хүрээгүй охидын биеэ үнэлэх явдал Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг томоохон суурин газарт нэмэгдсээр байна.

стратегийг хэрэгжүүлэх арга замыг зөвлөлдсөн байна. Улсын мэргэжлийн хяналтын газрынхан оролцсон энэхүү сургалтын үеэр хүүхдийн хөдөлмөрийн хяналтын үндэсний бодлого хэрэгтэй байгааг хүлээн зөвшөөрч, тус байгууллага хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар дагнан ажиллах нэг улсын байцаагчийг ажиллуулах болсон байна.

**375.** Албан бус хэвшилд хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн хамгааллын тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна.

**376.** Хүүхдийн эрхийн хорооноос хурдан морь унаач хүүхдийн талаар өгсөн зөвлөмжийн хэрэгжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авлаа:

- Хурдан морины уралдааныг зохицуулсан хууль эрх зүйн актыг шинэчлэн боловсрууллаа. Хурдан морины уралдааны шинэчилсэн дүрмийг хавсаргав.
- Хурдан морь унаач хүүхдийн үндэсний чуулганыг 2006 онд зохион байгуулж, түүнд 300 орчим хүнийг оролцуулав. Мөн хурдан морь унаач хүүхдийн аюулгүй байдлыг хангах талаар уяачидтай зөвшилцөж, талууд хамтран ажиллах Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан байна. Хүний эрхийн Үндэсний Комисс, Хүүхдийн төлөө үндэсний газар, Биеийн тамир, спортын улсын хороо, Олимпын үндэсний хороо, Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдааныг зохион байгуулах хороо, Морин спортын үндэсний холбоодын хооронд байгуулсан энэхүү санамж бичигт хурдан морь унаач хүүхдийн эрх ашгийг хамтран хамгаалахаар тусгасан байна.
- Үндэсний спортын нэг төрөл болох хурдан морины уралдааныг хөгжүүлэхэд унаач хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр Засгийн газрын 2006 оны 150 дугаар тогтоолоор баталсан “Үндэсний спортыг хөгжүүлэх хөтөлбөр”-т хурдан морь унаач хүүхдийн аюулгүй байдлыг хангах ажлыг тусгах, унаач хүүхдийн хамгаалалтын хувцасны стандартыг боловсруулах, Биеийн тамир, спортын тухай хуулийн 3.1.4, 3.1.5, 3.1.8 дахь заалтад Улсын дээд шүүхийн тайлбар гаргуулах зэрэг асуудлыг Хүүхдийн төлөө үндэсний газар, Биеийн тамир спортын улсын хороо хамтран судалж байна.

### **Мансууруулах бодисын хэрэглээ**

**377.** Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 12 дугаар зүйлд “мансуурах донтой этгээд сайн дураараа эмчлүүлэх хүсэлт гаргавал ердийн журмаар, эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр бол албадан эмчлэхээр” заасан байна. Түүнчлэн насанд хүрээгүй хүүхдэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг худалдах, олгохыг хориглосон байна. Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэдэг, садар самуунд өртсөн хүүхдийг цагдаа, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн болон төрийн бус байгууллага, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн байнгын хяналтад байлгаж, эмчлэх, сувилах, хүмүүжүүлэх арга хэмжээ авахаар хуульчилсан байдаг.

**378.** Улсын хэмжээнд 2004 онд 18, 2005 онд 20, 2006 онд 23 насанд хүрээгүй хүн мансууруулах бодист хэрэглэсэн<sup>23</sup> байна. Хүн амыг хар тамхи, мансуурах бодисоос

<sup>23</sup> Мансуурлын эсрэг үндэсний төв

хамгаалах нийгэмлэг 1999 оноос эхлэн жил бүр томоохон суурин газарт 1000 орчим сурагч, оюутны дунд тандалтын судалгаа явуулж ирсэн бөгөөд мансууруулах бодисын хэрэглээ өсөж байгааг нотолж байна. Эдгээр судалгаагаар мансууруулах бодис хэрэглэсэн гэж хариулсан 13–18 насны хүүхдийн 75 хувь нь каннибас, 11 хувь нь сэтгэцэд нөлөөлөх эм, 9 хувь нь үнэрт бодис, 4 хувь нь тариа хэрэглэж байгаа нийтлэг дүр зураг гарсан байна.

**379.** Монгол оронд Cannabis Ruderalis төрлийн ургамал манай орны газар тариалангийн бус нутаг болон тал хээрийн нутгаар зонхилон ургадаг хэдий ч ТНС агуулах хэмжээгээр харьцангуй бага, тарималжаагүй байна. Мансуурлын эсрэг тэмцэх ажлын хүрээнд мансууруулах үйлчилгээтэй ургамлын 300 орчим га газрын 100 орчим га–д устгал хийсэн байна. Мансуурах зуршилтай хүүхэд, иргэдийг эмчлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын тушаалаар Сэтгэцийн клиникийн эмнэлэг, Наркологийн үндэсний төвийг нэгтгэн Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийг 2006 онд зохион байгуулсан байна.

**380.** Монгол Улсад сэтгэцэд нөлөөлөх 11 төрлийн эм хэрэглэж байна. Үүнээс аминазан, галиоперидол зэрэг эм гаж нөлөө ихтэй, үйлчилгээ тааруу учир хэрэглэхээс татгалзаж байна. Гэвч шинэ төрлийн эмийг эмчилгээнд хэрэглэхэд өндөр өртөгтэй тал байна.

**381.** Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Мансуурлын эсрэг үндэсний төв, Нийслэлийн Цагдаагийн газар, Хүүхэд, залуучуудын газар хамтран мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөл, түүнээс урьдчилан сэргийлэх талаар ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн хөтөлбөрт тусгах санал боловсруулсан байна. “Сургууль мансууралтгүй орчин” хөтөлбөрийг ерөнхий боловсролын 12 сургуулийг сонгон хэрэгжүүлж, тэдэнд мансууруулах эм бодис, түүний хор уршгийн талаар сурталчлах “Үе тэнгийн сургагч”–аар 140 хүүхдийг бэлтгэлээ. Мөн “Өсвөрийн үе тэнгийн сургагч багш” гарын авлага ном, хэдэн төрлийн зөвлөмжийг 1200 хувь хэвлэн тараасан байна.

Мансууралтай тэмцэх үйл ажиллагаанд Хүн амыг хар тамхи, мансуурах бодисоос хамгаалах нийгэмлэг, Архидалтын эсрэг үндэсний төв, Ухаарахуй нийгэмлэг зэрэг төрийн бус байгууллагууд идэвхтэй хамтран ажиллаж, олон нийт, өсвөр үеийнхэнд архи, мансуурах бодисын хор хөнөөлийг сурталчилж, мэргэжлийн зөвлөгөө үзүүлж байна.

**382.** Мансууруулах эм бодис, түүний хор уршгийн чиглэлээр хүүхэдтэй ажилладаг сэтгэл зүйч, нийгмийн ажилтан болон урьдчилан сэргийлэх ажиллагааг удирддаг цагдаагийн хүүхдийн байцаагч нарт зориулсан арга зүйг боловсруулах, түгээх, сургах эрэлт хэрэгцээ, шаардлага нэлээд өсөж байна.

### **Бэлгийн мөлжлөг, бэлгийн хүчирхийлэл**

**383.** Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг нэмэлт протоколыг хэрэгжүүлэх зорилго бүхий “Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр”–ийг Монгол Улсын Засгийн газрын (2005 оны 11 дүгээр сарын 30–ны өдрийн 234 дүгээр) тогтоолоор баталж, мөрдүүлж байна. Энэхүү үндэсний хөтөлбөрт хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор

ашиглахаас хамгаалах чиглэлээр зургаан төрлийн стратегийн зорилтыг дэвшүүлсэн байна:

- (1) Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгт ашиглахын эсрэг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу хүлээсэн үүрэг, бусад баримт бичигт туссан үйл ажиллагааг үндэсний түвшинд хэрэгжүүлэх;
- (2) Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгт ашиглах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, тэмцэхтэй холбогдсон эрхзүйн орчныг боловсронгуй болгох;
- (3) Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгт ашиглахаас хамгаалах, тэднийг садар самуунд уруу татах, дотооддоо болон хил дамжуулан худалдах гэмт хэрэг, түүний улмаас хүүхэд, эмэгтэйчүүдэд учирч болох хохирол, гарах үр дагаврын талаарх иргэний нийгэм, эцэг эх, хүүхэд, залуучуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх;
- (4) Нийгмийн ажилтан болон боловсрол, аялал жуулчлал, үйлчилгээ, хууль хяналтын байгууллагын ажилтны чадавхийг бэхжүүлж, хүүхэд, эмэгтэйчүүдтэй ажиллах мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх;
- (5) Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгт ашиглах, дотооддоо болон хил дамжуулан худалдагдахаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, хохирогчийг нөхөн сэргээх, нийгэмшүүлэхэд төрийн, иргэний нийгмийн болон олон улсын байгууллагын оролцоог нэмэгдүүлж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах;
- (6) Хүн худалдах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх, нийгэмшүүлэхэд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, тэдний зүгээс гарсан санал санаачилгыг дэмжиж ажиллахаар тусгасан байна.

**384.** Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахтай тэмцэх чиглэлээр үндэсний хэмжээнд 30 гаруй төрийн бус байгууллага нэгдэн Хүүхдийг биеийг нь үнэлүүлэх, бэлгийн мөлжлөг ба бэлгийн зорилгоор садар самууны үзүүлбэрт ашиглах, дамжуулан худалдаалах явдлыг устгах ЭКПАТ–ын үндэсний сүлжээг 2003 оны 11 сард байгуулж, улмаар 2004 оны 2 сараас Олон улсын ЭКПАТ–ын сүлжээний гишүүнээр элсэн ажиллаж байна.

**385.** Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, НҮБ–ын Хүүхдийн сантай хамтран “Хүүхдийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, худалдаалахаас хамгаалах” төслийг 2002–2006 онд хэрэгжүүлсэн байна. Төслийн хүрээнд төрийн бус байгууллагууд хүүхдийн эсрэг хүчирхийллийн эсрэг, хил дамжуулан худалдахын эсрэг зэрэг сурталчилгааны материалыг хэвлүүлэн хот, хөдөөд тараан түгээсэн байна.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн дэлхийн судалгааны тайлан, Хүүхэд хамгааллын талаар парламентын гишүүдэд зориулсан гарын авлага зэргийг монгол хэлээр орчуулан хэвлүүлж тараасан байна. НҮБ–ын Хүүхдийн сан, Нийслэлийн цагдаагийн газар хамтран баруун бүсийн (Увс, Ховд, Баян–Өлгий, Завхан, Говь–Алтай) 5 аймгийн цагдаагийн газар, хэлтэс, хэсгийн төлөөлөгч, хүүхдийн байцаагч, хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагын ажилтанд зориулан “Хүн худалдах, ялангуяа хүүхэд,

эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах” сэдэвт сургалтыг 2007 оны 6 дугаар зохион байгуулсан байна.

Хүүхдийн эрхийн үндэсний төв төрийн бус байгууллагаас 2005–2007 онд хүүхэд, эмэгтэйчүүдийг хил дамжуулан худалдаалах болон бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэхээр “Сүүдэр” сониныг улирал тутам (2000 хувь) хэвлүүлэн үнэгүй тарааж байна. Хүйсийн тэгш эрхийн төв төрийн бус байгууллагаас “Хүн худалдах гэмт хэрэг”-ийн сургагч багшид, “Хүүхдийн эсрэг хүчирхийлэл”-ийн нийгмийн ажилтанд, “Та үүнийг мэдэх үү” олон нийтэд зориулсан цуврал болон “Хүүхдийн бэлгийн хүчирхийлэл” цагдаагийн ажилтны гарын авлага зэргийг хэвлүүлсний зэрэгцээ “Хохирогч”, “Хүн худалдах гэмт хэрэг гэж юу вэ?”, “Хэрвээ таны хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн бол...” зэрэг зөвлөмжийг гаргаж олон нийтэд түгээсэн байна.

**386.** Судалгааны тоо мэдээгээр 2001 онд 38, 2004 онд 215 охин бэлгийн мөлжлөгт өртсөн байна <sup>24</sup>. Нийслэлийн дүүргүүдийн цагдаагийн хэлтэс, Улсын мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын 2006 онд явуулсан хамтарсан шалгалтаар 325 байгууллага, аж ахуйн нэгжийг хамруулан шалгахад насанд хүрээгүй биеэ үнэлэгч охидыг цуглуулдаг 31 газрыг тогтоож, насанд хүрээгүй биеэ үнэлэгч 24 охиныг илрүүлэн ар гэрт нь хүлээлгэн өгөх, нийгэмшүүлэх төсөл, хөтөлбөрүүдэд хамруулах, энэ төрлийн гэмт хэрэгт зуучилдаг, зохион байгуулдаг 3 хүнд хуулийн дагуу арга хэмжээ авсан байна.

**387.** Хүүхдийг бэлгийн мөлжлөг, бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирсон хүүхдэд нөхөн сэргээх, нийгэмшүүлэх үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагаанд төрийн бус байгууллагууд идэвхтэй оролцож байна. Тухайлбал,

Хүүхдийн эрхийн үндэсний төв бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгт орсон охидод зөвлөгөө өгөх төсөл хэрэгжүүлж, “Охидын яаралтай тусламж” гэсэн 7 бүлэг бүхий гарын авлага номыг хэвлүүлэн хараа хяналтгүй 61 охидод эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж, 25 охиныг нийгэмшүүлэх ажил хийсэн байна. Хүний эрх хөгжил төв 1998 оноос эхлэн хүн худалдаалах гэмт хэргийн асуудлаар судалгаа явуулж, холбогдох байгууллагын ажилтнуудыг чадавхижуулах талаар багц сургалт явуулах, бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдэд өмгөөллийн туслалцаа үзүүлэх, хууль зүйн зөвлөгөө өгөх, хууль эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийх, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг санаачлан боловсруулах зэргээр идэвхитэй ажиллаж байна.

Тэгш мөр төв 2004 оноос зах дээр хөдөлмөр эрхэлдэг өсвөр насны охидыг бэлгийн мөлжлөг, хүчирхийллээс хамгаалах ажлыг явуулж, энэ хугацаанд 116 охидыг бэлгийн мөлжлөгөөс хөндийрүүлж, 60 гаруй охиныг нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээнд хамруулсан байна.

**388.** Насанд хүрээгүй охидын биеэ үнэлэх эрсдэлд гэр бүлийн хүчирхийлэл, эдийн засгийн хүнд байдал, ядуурал зэрэг хүчин зүйл нөлөөлж байна.

**389.** Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөрт төрийн зарим чиг үүргийг төрийн бус

<sup>24</sup> Монгол Улсын хүүхэд, эмэгтэйчүүдийн байдал, НҮБ-ын Хүүхдийн Сан, 2007



байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх тухай тусгасан байна. Гэвч одоогоор гэрээгээр төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэж байгаа байгууллага байхгүй байна.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран хэрэгжүүлдэг “Хүүхэд хамгаалал” хөтөлбөрийн хүрээнд 2005 оноос хойш жил бүр 10000 ам доллартай тэнцэх хэмжээний хөрөнгийг хүүхдийг бэлгийн мөлжлөгөөс сэргийлэх ЭКПАТ–Монгол үндэсний сүлжээний үйл ажиллагааг дэмжин санхүүжүүлж байна. ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн устгах хөтөлбөрөөс 2001–2002 онд 23000, 2003–2005 онд 28000, 2006–2009 онд 65000 ам. долларыг төсөвлөн Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны удирдлага, хяналтаар хэрэгжүүлж байна.

**390.** Гэвч насанд хүрээгүй охидыг садар самуунд татах, бэлгийн зорилгоор ашиглах сонирхол тодорхой бүлгийн дунд нэгэнт бий болжээ. Энэ үйл ажиллагаа нарийн зохион байгуулалтад шилжиж, үйл ажиллагааны хамрах хүрээ нь нэмэгдэж байна. Гэмт бүлэглэлүүд охидыг дарамт, хүчирхийллийн аргаар бөөнөөр байрлуулж, тэднийг бэлгийн зорилгоор ашиглах үйл ажиллагаанд зуучлан худалдаж байна. Энэ байдал охид, эмэгтэйчүүдийг хил дамнуулан худалдах эхлэл болж байна. Садар самуунд татагдсан, бэлгийн зорилгоор ашиглагдсан насанд хүрээгүй хүмүүсийн талаар нөхцөл байдлыг тодорхойлсон судалгаа, шинжилгээ, үнэлгээ ажил хийгдээгүй бөгөөд энэ талаар мэдээлэл алга байна.

**391.** Бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогчид үзүүлэх үйлчилгээ, хамгаалах тогтолцоо хангалттай бус, энэ чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн цар хүрээ бага, нэг удаагийн, түр зуурын шинжтэй, хохирогчдын эрэлт хэрэгцээнээс хол хөндий, бодит байдалд нийцээгүй нэр төдий сургалт, зөвлөгөөнөөс цааш хэтрэхгүй байна. Хүүхэд, өсвөр үеийг бэлгийн хүчирхийлэл, дарамтаас сэргийлэх, хохирогчдод нөхөн сэргээх, яаралтай тусламж үзүүлэх засаг захиргаа, цагдаа, шүүх, нийгмийн хөгжлийн байгууллагын ажилтны хандлага дорвитой өөрчлөгдөхгүй байна.

### **Хүүхдийг худалдаалах, хил дамжуулан худалдах болон хүүхдийг хулгайлах**

**392.** Засгийн газраас Хүүхдийн эрхийн хорооны зөвлөмжийн 65 дугаар заалтад туссан хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг тэмцэх үйл ажиллагааг улам эрчимжүүлэх шаардлага гадаад, дотоод олон хүчин зүйлийн улмаас нэмэгдэж байна. Тухайлбал, Залуучуудад гадаадад суралцах, ажиллах, амьдрах, гадаадын иргэнтэй гэр бүл болох сонирхол нэмэгдэж, аялал жуулчлалын хүрээ байнга тэлж байна.

**393.** Хүүхдийг худалдах, садар самууныг сурталчлахтай тэмцэх чиг үүргийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, тэдгээрийн харьяа агентлаг, бүх шатны Засаг дарга, түүний тамгын газар зэрэг төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд хүлээж ажиллаж байна.

**394.** Хүүхдийг хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Монгол Улсын хилээр орж гарах мэдүүлэг дээр “дагалдан яваа хүүхэд” гэсэн асуултыг нэмж оруулсан байна. Хилээр зорчигч хүүхэд дагуулж яваа бол хүүхдийн нэр, овог, нас, регистрийн дугаарыг мэдүүлэх ёстой бөгөөд энэ мэдээлэл нэгдсэн санд хадгалагдаж хүүхэд эх орондоо ирсэн эсэхийг хянах боломж олгож байна.

**395.** Хүн худалдах гэмт хэрэг, хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгөөс сэргийлэх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг нийтэд сурталчлах, байгууллагуудын мэдээлэл солилцох, холбоо тогтоох, харилцах зорилготой [www.stoptrafficking.mn](http://www.stoptrafficking.mn), [www.ecpat.mn](http://www.ecpat.mn); [www.stopchildabuse.mn](http://www.stopchildabuse.mn), [www.naiznet.mn](http://www.naiznet.mn) зэрэг вэб хуудас ажиллуулж байна.

Сүлжээнд нэгдсэн байгууллагууд хохирогч хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, ДОХ, ХДХВ-ийн мэдлэг олгох, боловсролыг нөхөн олгох, мэргэжлийн сургалтад хамруулах, сэтгэлзүйн болон хуулийн зөвлөгөө өгөх, олон нийтийн ойлголт, хандлагад нөлөөлөх, хамтран ажиллах байгууллага, мэргэжилтнийг чадавхжуулах ажлыг явуулж байна. Хэвлэл мэдээллийн ажилтныг чадавхжуулах сургалтад тогтмол хамруулах явдал үнэн бодит, зөв мэдээлээр хохирогчийн эрхийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, ойлголт, хандлагыг зөв төлөвшүүлэх, улмаар таслан шийдвэрлэх үйл явцыг олон нийтэд нээлттэй болгоход нөлөөлж байна.

**396.** “Хүн худалдах гэмт хэргийн өнөөгийн байдал”, “Үйлчилгээний газар ажиллаж байгаа болон хилийн боомт газар биеэ үнэлж байгаа залуу охид, эмэгтэйчүүдийн хандлага” зэрэг судалгааг төрийн бус байгууллагууд хийсэн байна.

**397.** Монгол Улсад насанд хүрээгүй хүнийг худалдах, хил давуулан худалдах болон хүүхдийг хулгайлсан шинжтэй гэмт хэрэг 2006 оны байдлаар нийт 5 бүртгэгдсэн байна:

- Биеийг нь үнэлүүлэх зоилгоор хил давуулан худалдсан 7 хохирогчтой 3 хэрэг гарсны нэгийг хэрэгсэхгүй болгож, 2 нь шүүхээр шийдэгдсэн байна. Хохирогч нь 15–17 насны хүүхэд болно.
- Гэр бүл болгох зорилгоор 17 настай хүүхдийг БНСУ руу худалдсан гэх хэрэг нэг бүртгэгдсэн хэдий ч энэ хэргийг хэрэгсэхгүй болгосон байна. Тэр охин БНСУ-ын иргэнтэй албан ёсоор гэр бүл болоогүй, худалдагдсан нь тогтоогдоогүй болно.
- Үрчлэх нэрээр худалдсан гэх хэрэг нэг бүртгэгдсэн, хохирогч охин 13 настай, БНХАУ-ын иргэн үрчлэн авсан ба худалдан авсан гэдэг нь тогтоогдоогүй тул хэргийг хэрэгсэхгүй болгосон байна.

#### **Бусад хэлбэрийн мөлжлөг**

**398.** Гэр бүлийн болон сургуулийн орчны хүчирхийллийн талаар тайлан илтгэлийн өмнөх бүлгүүдэд танилцуулсан болно.

#### **Г. Угсаатан, цөөнхөд харьяалагдах хүүхдүүд**

**399.** Угсаатан, цөөнхийн хүүхдийн амьдрах орчин, эрхийн байдлын чиглэлээр тайлангийн холбогдох бүлгүүдэд танилцуулсан болно.

#### **Д. Гудамжинд амьдарч буй хүүхдүүд**

**400.** Хүүхдийн эрхийн хорооны зөвлөсний дагуу Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хуулийг түтгэлзүүлэх, хараа хяналтгүй хүүхдэд үзүүлэх нөхөн сэргээх, нийгэмшүүлэх үйлчилгээг Хүүхдийн эрхийг хамгаалах тухай, Гэр бүлийн тухай хуульд шинээр тусгахаар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яамны хамтарсан ажлын хэсэг ажиллаж байна. Эдгээр хуулийн шинэчлэлийн агуулга нь хүүхдийг гэр бүлээсээ дайжихаас урьдчилан сэргийлэх, эцэг эхийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, хүүхдээ асрах,

гэр бүлийг дэмжих, гудамжинд гарсан хүүхдийг эцэг эхэд нь буцаах, эцэг эхийг сурган хүмүүжүүлэх нөлөөллийн үйл ажиллагаанд заавал хамруулахад чиглэж байна.

**401.** Хүүхэд гудамжинд гарахаас сэргийлэх, хараа хяналтгүй хүүхдийг гэр бүлд нь буцаах зорилгоор “Монголын үрс эцэг эхтэйгээ”, “Хүн байхын учир” зэрэг тодорхой зорилго, удирдамж аян, арга хэмжээг өрнүүлж байна. Эдгээр аян, арга хэмжээний нээлтийн ажиллагааг улсын хэмжээнд хараа хяналтгүй хүүхдүүд, эцэг эх, гэр бүл, олон нийтийн төлөөлөл бүхий 3000 гаруй хүнийг оролцуулан Улаанбаатар болон 4 аймагт бүсчлэн зохиосон байна.

Баян-Өлгий аймагт болсон арга хэмжээ нь казак үндэстний хүүхдийг асран хүмүүжүүлдэг онцлог, тэдний гэр бүлийн ёс журам, уламжлалыг эрхэмлэх үнэт зүйлсийг олон нийтэд түгээх, сурталчилахад түлхэц болсон юм. Энэ аяны хүрээнд бүтээсэн баримтат кино, гарын авлага, мэдээлэл болон телевизийн богино хэмжээний шторк, радио, телевизийн шууд нэвтрүүлэг зэрэг өргөн хүрээтэй сурталчилгаа хараа хяналтгүй хүүхдийн талаар олон нийтийн сөрөг хандлагыг багасгахад чухал нөлөө үзүүллээ. Аяны хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын удирдамж чиглэлээр орон нутагт салбар хороо байгуулан ажиллуулж байна.

Мөн хараа хяналтгүй хүүхдийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сүлжээг байгуулан хараа хяналтгүй хүүхдийг гэр оронд нь буцаах, боловсрол нөхөн олгох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааны ажилд оролцуулах, олон нийтийн зүгээс хүүхдэд тавих анхаарал халамжийг дээшлүүлэх ажлыг явуулж байна.

**402.** Нийслэлийн цагдаагийн газрын дэргэдэх Хүүхдийн хаяг тогтоох байрны үйл ажиллагаа, чиглэлийг өөрчлөн Халамж, үйлчилгээний төв болгосон байна. Энэ төв нь хараа хяналтгүй, эцэг эхээсээ төөрсөн хүүхдийг эцэг эхийг нь олох, хаягийг тогтоох хүртэл болон хүүхдийг гэр бүлд буцаан өгөх хүртэл хугацаанд хүүхдийн халамж, хамгааллын үйлчилгээг үзүүлэх чиг үүрэгтэй болсон байна. “Монголын үрс эцэг эхтэйгээ” “Аяны хүрээнд Халамж, үйлчилгээний төвөөс хүүхдэд нийгмийн үйлчилгээ үзүүлэхэд 95.8 сая төгрөг зарцуулаад байна.

**403.** Хүүхдийн эрхийн үндэсний төвөөс хүүхдийн халамж, асрамжийн төвүүд болон гудамжинд амьдарч байсан 1817 хүүхдийг хамарсан хараа хяналтгүй хүүхдийн нийгэмшилтийн байдалд 2006 онд үнэлгээ хийсэн байна. Үнэлгээний дүнгээс үзэхэд хүүхдийн 45 хувь нь өөрсдөө энэ замыг сонгосон, 34 хувь нь гэр бүлийн хүчирхийллээс зугтсан, 21 хувь нь бусад шалтгаанаар гэр бүлээсээ дайжсан гэж мэдээлсэн байна. Нийслэлийн цагдаагийн газар 2006 оны байдлаар 282 хүүхэд халамж, асрамжийн төвд хааяа очсон шиг ихэвчлэн гадуур сэлгүүцэж, хараа хяналтгүй байдлаар амьдарч байгааг мэдээлж байна.

#### **Хүүхдийн эрхийн тухай конвенцийн нэмэлт протоколын мэдээлэл**

**404.** Монгол Улсын Засгийн газар Хүүхдийн эрхийн тухай конвенцийн Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг болон Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахаас хамгаалах талаарх Нэмэлт протоколуудын анхны тайланг боловсруулан энэхүү тайлан илтгэлийн хамт Хүүхдийн эрхийн хороонд өргөн барьсан болно.

**Тайлан илтгэлийн нэгдсэн дүгнэлт**

Монгол Улсаас Хүүхдийн Эрхийн Хороонд танилцуулсан хоёрдугаар илтгэлд тус хорооноос өгсөн дүгнэлт, зөвлөмж болон Хүүхдийн эрхийн конвенцийг хэрэгжүүлэх чиглэлд Монгол Улсын Засгийн Газар тайлант хугацаанд ихээхэн чармайлт, анхаарал тавьж ажилласны дүнд хүүхдийн аж байдал, амьдралд олон эерэг нөлөөллүүд гарч байна.

Монгол Улсын Засгийн Газар энэ тайланд үндэслэн цаашид өнөөгийн хүрсэн түвшинг хадгалах замаар хүүхдийн аж байдал, амьдралыг сайжруулахын тулд дараах асуудалд анхаарч ажиллах болно. Үүнд:

- Хүүхдийн эрхийг хангах, хамгаалахтай холбоотойгоор Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, түүний ажлын алба болох Хүүхдийн төлөө үндэсний газрын үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай байна. Ялангуяа хүүхдийн эрхийн тухай конвенц, бодлогын баримт бичгүүдийг мэдээлэх, сурталчлах, хэрэгжилтэнд хяналт тавих, үр дүнг тайлагнах үйл ажиллагаа дутагдаж байна.
- Монгол Улсад хүүхдийн эрхийг хамгаалахтай холбоотой бодлогын болон хууль эрх зүйн олон тооны баримт бичиг батлагдан гарч байгаа ч захиргааны үйл ажиллагаанд ашиглагдахгүй тунхаглалын шинжтэй хэвээр байна. Төрийн захиргааны бүх шатны байгууллагууд, үүний дотор бүх шатны Засаг дарга хүүхдийн эрхийг хамгаалах талаар өөрт ноогдсон бүрэн эрх, үүргээ ашиглахгүй байгаагаас хүүхдийн эрх зөрчигдөх асуудал гарсаар байна. Хүүхдийн эрхийг хамгаалах үүргээ биелүүлэхгүй байгаа төрийн албан хаагчтай хариуцлага тооцох олон нийт, эцэг эхийн санаачлага, шахалт дутагдаж байна.
- Хүүхэд хамгааллын олон асуудлууд бодлогын болон хэрэгжүүлэх түвшинд эзэнгүйдсэн хэвээр байгааг богино хугацаанд шийдвэрлэх шаардлага тулгарч байна. Хүүхдийг эрсдлээс урьдчилан сэргийлэх, шуурхай болон урт хугацаанд хамгаалах, нөхөн сэргээх хувилбарт үйлчилгээг хөгжүүлэх, олон нийт, иргэд, мэргэжлийн болон иргэний нийгмийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх тогтолцоо үгүйлэгдэж байна.
- Хүүхдийн хөгжил, хамгааллын талаарх мэдээллийн нэгдмэл тогтолцоо алга байна. Хүүхдийн аж байдал, эрхийн хэрэгжилтийг дүгнэх мэдээллийн нэгдсэн санг үндэсний болон орон нутгийн түвшинд байгуулах, мэдээлэл цуглуулах, нэгтгэх маягт, агуулгыг нэг хэлбэрт оруулах асуудал байна.
- Хүүхдийн эрхийг хамгаалах арга зүйг үндэсний уламжлалдаа нийцүүлэн хөгжүүлж шинэчлэх нь чухал байна. Нийгэм бүхэлдээ хүүхдээ тэвчээртэй сонсдог, тэдний эрхийг хүндэтгэдэг, хүүхдийн оролцоог бүхий л шатанд хүлээн зөвшөөрөх нийгмийн хандлагыг хөгжүүлэх асуудал тулгарч байна.
- Хүүхдийн олгож байгаа боловсролын хүртээмжийг сайжруулахын хамт олон улсын түвшинд өрсөлдөх чадавхитай дэлхийн хүнийг төлөвшүүлэхэд чиглэсэн чанарын тогтолцоо бий болгох шаардлага байна. Хүүхдийн хөгжил нь тэдний эрүүл мэндийн үйлчилгээтэй салшгүй холбоотой. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээг сайжруулах, 0–5 хүртэлх насны хүүхдэд эм, эмийн бэлтгэлийг үнэ төлбөргүй олгох тогтолцоог бий болгох асуудлыг судлан шийдвэрлэх шаардлага байна.

**6.5 ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ  
МОНГОЛ УЛСЫН ГУРАВ, ДӨРӨВДҮГЭЭР ИЛТГЭЛИЙГ ХЭЛЭЛЦЭЭД  
НҮБ-ЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХОРООНООС ӨГСӨН ЗӨВЛӨМЖ**

**Хүүхдийн эрхийн хороо  
53 дугаар хуралдаан**

**КОНВЕНЦИЙН 44 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН ДАГУУ ГИШҮҮН УЛСЫН  
ӨРГӨН БАРЬСАН ИЛТГЭЛД ӨГӨХ ДҮГНЭЛТ ЗӨВЛӨМЖ:**

2010 оны 1 дүгээр сарын 11–29

**МОНГОЛ УЛС**

1. Хүүхдийн эрхийн хороо нь Монгол Улсын гурав, дөрөвдүгээр илтгэлийг (CRC/C/MNG/3–4) 2010 оны 1 дүгээр сарын 12 болон 13–нд 1456, 1458, 1460 дүгээр (CRC/C/SR.1456, 1458 болон 1460–р хуралдаанаар) хэлэлцэж 2010 оны 1 дүгээр сарын 29–ны өдрийн 1501 дүгээр хуралдаанаар дараах зөвлөмжийг гаргав.

**А. Оршил**

2. Гурав, дөрөвдүгээр тайлан илтгэлийг тайлагнах хүрээнд Монгол Улсын бичгээр өгсөн хариултыг (CRC/C/MNG/3–4 and CRC/C/MNG/Q/3–4/Add.1) талархан хүлээн авснаа илэрхийлэхийн ялдамд тус улсын өндөр хэмжээний төлөөлөгч өөрийн орны хүүхдийн нөхцөл байдлын талаар илүү сайн ойлголт өгөх үр дүнтэй хэлэлцүүлэгт хүрэлцэн ирж оролцсонд Хүүхдийн эрхийн хороо талархал илэрхийлж байна.

3. Энэхүү дүгнэлт зөвлөмжийг 2010 оны 1 дүгээр сарын 29–нд Хорооноос хамтад нь баталсан Монгол Улсын Нэмэлт Протоколуудын хэрэгжилтийн тухай анхны тайлангуудад (CRC/C/OPSC/MNG/CO/1) болон (CRC/C/OPAC/MNG/CO/1) өгсөн зөвлөмжүүдтэй нийлээд нэгэн цогц баримт бичиг гэж үзэхийг Монгол Улсаас хүсье.

**В. Өмнөх илтгэлийн мөрөөр Гишүүн улсын авсан арга хэмжээ болон олсон амжилт**

4. Хүүхдийн эрхийн тухай конвенцийг хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр дараах хуулийг баталж, бусад арга хэмжээг авсныг Хороо сайшаан тэмдэглэж байна:

- a) Давсыг иоджуулснаар иодын дутагдлаас сэргийлэх тухай хууль (2003);
- b) Хүний дархлал хомсдлын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хууль (2004);
- c) Эхийн сүүг орлуулагч бүтээгдэхүүний тухай хууль (2005);
- d) Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн халамжийн тухай хууль (2005);
- e) Хүүхэд гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хууль (2006)

5. Гишүүн орон дараах хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулсан явдлыг Хороо мөн сайшаан тэмдэглэж байна.

- а) Нийгмийн халамжийн тухай хууль (2005);
- б) Боловсролын тухай хууль (2006); болон с) Эрүүгийн байцаан шийтгэх хууль (2007);

6. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцид Монгол улс шинээр нэгдэн (2009), Эдийн засаг, Нийгэм, Соёлын Эрхийн тухай Олон улсын пактын Нэмэлт Протоколд гарын үсэг зурсан явдалд Хороо талархлаа илэрхийлж байна.

### **С. Гол асуудал болон зөвлөмж**

#### **1. Хэрэгжилтийн ерөнхий арга хэмжээ** (Конвенцийн 4, 42, 44 дүгээр зүйл болон 6 дугаар зүйл)

7. Монгол Улс өөрийн хоёр дахь тайлан илтгэлтэй холбоотой (CRC/C/65/Add.32, 2005) зарим асуудал, зөвлөмжийг шийдвэрлэсэн явдалд Хороо талархлаа илэрхийлж байна.

Гэвч бусад асуудлуудыг хангалтгүй хэмжээнд, багахан хэсгийг нь шийдвэрлэсэнд харамсаж буйгаа илэрхийлье.

8. Өмнөх дүгнэлт зөвлөмжид туссан боловч дутуу хагас хэрэгжсэн, эсвэл огт хэрэгжээгүй зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх, энэхүү шинэ дүгнэлт зөвлөмжид багтсан зөвлөмжүүд, тэр дундаа, хууль тогтоомж, мэдээлэл цуглуулах, ялгаварлан гадуурхахгүй байх, бие махбодын шийтгэл, үрчлэлт, хүчирхийлэл, үл хайхрах байдал, ёс бус харилцаа, амьдралын түвшин, гудамжны хүүхдийн талаарх зөвлөмжүүдийг хангалттай хэмжээнд хэрэгжүүлэх талаар шаардлагатай бүх арга хэмжээг авахыг Гишүүн орноос Хороо шаардаж байна.

#### **Хууль тогтоомж**

9. Монгол Улс дотоодын хууль тогтоомжоо Конвенцтой нийцүүлэх талаар хичээл зүтгэл гаргасан гэдгийг Хороо тэмдэглэж байгаа ч гэсэн, зарим хууль тогтоомжийн заалтууд Конвенцийн зарчим, заалтуудтай бүрэн уялдаж чадахгүй байгаа, хууль тогтоомжийн хэрэгжилт нь удаан байгаад Хороо сэтгэл зовниж байна.

10. Гишүүн улс өөрийн хууль тогтоомжийг Конвенцийн зарчим, заалтуудтай уялдуулж, дотоодын хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулахыг Хороо дахин зөвлөж байна. Мөн Гишүүн улсыг Хүүхдийн эрхийн талаар цогц хуулийг боловсруулж хэрэгжүүлэхийг шаардаж байна.

#### **Зохицуулалт**

11. Хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх улс төрийн сонирхол нь хүүхдийн асуудал хариуцсан гурван байгууллагын үйл ажиллагаанд туссан байгааг Хороо сайшааж байна. Гэвч, эдгээр байгууллагууд нь бүх түвшинд хангалттай хэмжээнд хамтран ажиллахгүй байгаад Хороо сэтгэл зовниж буйгаа илэрхийлье. Мөн хүүхдийн эрхийн хэрэгжилтийн

механизмыг бүх түвшинд, тэр дундаа орон нутагт тодруулах шаардлагатайг зөвлөж байна. Хүүхдийн Төлөө Үндэсний зөвлөл нь төлөвлөснийхээ дагуу хуралдахгүй, үйл ажиллагаа явуулахгүй байгаад шүүмжлэлтэй хандаж байна.

12. Гишүүн орныг дараах зүйлийг анхаарахыг Хороо дахин зөвлөж байна.

- a) Хүүхдийн эрхийн бодлого боловсруулалт, хэрэгжилтийг хариуцсан үндэсний болон орон нутгийн төрийн байгууллагуудын бүтцийг дахин хянаж үзэх;
- b) Хүүхдийн төлөө үндэсний газрыг тохируулагч агентлагийн статустайгаар ажиллах эрхтэй болгож, үүргээ гүйцэтгэхэд нь хангалттай хэмжээний санхүү болон хүний нөөцөөр хангаж өгөх.

### **Үндэсний хөтөлбөр**

13. 2002–2010 оны хооронд хэрэгжүүлж буй Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийг сайшааж байгаа хэдий ч, үүний хэрэгжилт, хяналт, үнэлгээний механизмын талаар мэдээлэл өгөөгүйд харамсаж байна. Мөн 2007 оноос хойш хүүхдийн эрхийн талаар Үндэсний хөтөлбөр байгаа эсэх талаар мэдээлэл дутмаг байгаад харамсаж байна. Мөн хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх, хөхиүлэн дэмжих талаар үндэсний хэмжээний цогц төлөвлөгөө байхгүй байгаад сэтгэл зовниж байна.

14. Гишүүн улсад дараах зөвлөгөөг Хороо өгч байна.

- a) 2002–2010 оны хугацаанд хэрэгжүүлж буй Үндэсний хөтөлбөрт үнэлгээ, мониторинг хийх;
- b) Иргэний нийгэм зэрэг бүх холбогдох талуудтай хамтран зөвлөлдсөний үндсэн дээр 2010 оноос хойших Үндэсний хөтөлбөр, цаашлаад үүний хэрэгжилтэнд гарсан ахиц, сул талуудыг илрүүлэх үүднээс үнэлгээ хийж, хэрэгжилтийн мөрөөр авах арга хэмжээний механизмыг боловсруулан баталж, хэрэгжүүлэх, үүнд зориулж хангалттай хэмжээний санхүү болон хүний нөөцийг хуваарилах.

### **Бие даасан хяналт**

15. Хүний эрхийн Үндэсний Комиссын хэрэгжүүлж буй арга хэмжээ болон Комиссын гурван гишүүний нэг нь хүүхдийн эрхийн асуудлыг хариуцсан бүрэн эрхтэй болсон явдлыг Хороо сайшаан тэмдэглэж байна. Хэдий тийм ч, хүүхдүүд өөрсдөө гомдол мэдүүлэх боломжгүй байгаад Хороо сэтгэл зовниж байна.

16. Хүүхдийн эрхийг сурталчлах, хамгаалах талаар хүний эрхийн бие даасан үндэсний байгууллагын үүргийн талаар Хорооноос гаргасан 2 дугаар ерөнхий тайлбарыг харгалзан үзсэний үндсэн дээр Хүний эрхийн Үндэсний Комисс дээр хүүхдэд ээлтэй, хүртээмжтэй, гомдол хүлээж авах механизмыг бүрдүүлэх, хүүхдийн эрх зөрчигдсөн үед арга хэмжээ авах чадвар, эрх мэдэлтэй байх, хүүхдээс өөрсдөөс нь гомдол хүлээн авах эрхтэй, чадвартай болгох талаар шаардлагатай бүх арга хэмжээг авахыг Гишүүн улсад Хорооны зүгээс уриалж байна.

### Нөөцийн хуваарилалт

17. Гишүүн улс нийгмийн салбар, тэр дундаа боловсролын салбарын төсвийг үндэсний нийт төсвийн 20 хүртэлх хувь болтол нэмэгдүүлэхэд хүч чармайлт гарган ажиллаж байгаад талархаж байна. Хэдий тийм ч, эдийн засгийн хямрал, инфляци, мөн авлигал нь хүүхдийн эрхийн хэрэгжилтэнд зарцуулж буй хөрөнгө оруулалтын тогтвортой байдалд нөлөөлж, хүүхэд үндсэн эрхээ эдлэх нөөц бололцоог дутмаг болгох эрсдэлд оруулж байгаад сэтгэл зовниж байна. Өргөн уудам нутагтай улсын хувьд бүс нутаг, орон нутаг, хотын ялгаатай байдал нь одоо хэрэгжиж буй дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүдийн үр шимийг зарим бололцоогүй гэр бүл, хүүхдүүд хүртэхэд бэрхшээлтэй болгож байгаад Хороо сэтгэл зовниж буйгаа илэрхийлье. Мөн Хүүхдийн мөнгө хөтөлбөрийг зогсоохоор болсон Засгийн газрын шийдвэрт харамсаж байна.

18. Хороо Гишүүн оронд дараах зүйлийг зөвлөж байна

- a) Олборлолтын үйл ажиллагааны ашиг орлогоор бүрддэг Хүний хөгжлийн санд хуримтлагдсан хөрөнгө зэрэг нөөц бололцоог хүүхдийн төлөө зориулах явдлыг нэмэгдүүлэх;
- b) Үндэсний төсвийн хүүхдэд зориулж хуваарилсан хөрөнгийг (боловсрол, эрүүл мэнд, хүчирхийллээс сэргийлэх, чөлөөт цаг) гадаад, дотоодын эдийн засгийн аливаа хямрал, байгалийн гамшгийн нөлөөллөөс хамгаалах. Үүнтэй холбогдуулан, хүүхдэд зориулан хэдий хэмжээний хөрөнгө мөнгийг хэр үр ашигтай зарцуулж байгааг улсын төсвийн зарцуулалтаас харж болохуйц үзүүлэлтүүдийг нэвтрүүлэх. Ийм үзүүлэлтүүдийг боловсруулж, нэвтрүүлэхдээ шаардлагатай бол олон улсын байгууллагын дэмжлэг авахыг зөвлөж байна.
- c) Дараах чиглэлээр арга зүйг нэвтрүүлэх
  - Хүүхдийн хөгжилд төсөв хөрөнгийн үзүүлэх бодит нөлөөг хангахын тулд үр дүнд суурилсан төсөвлөлт,
  - Хот хөдөөгийн ялгаа, бүс нутгийн ялгаатай байдлыг багасгах, түүнчлэн зарим газар ундны усны хангамжийн нэмэгдүүлэх, боловсролын дэд бүтцийг байгуулах зэрэг тодорхой зорилгод чиглэсэн стратегийн төсөвлөлт,
- d) Хүүхдэд зориулж буй төсвийн урсгал, хөдөлгөөнийг ил тод, тогтмол хэмжиж байхад чиглэсэн хэрэглэгчдэд ээлтэй шалгуур үзүүлэлтийн тогтолцоог бий болгох,
- e) Хүүхдэд зориулж буй нөөц бололцооноос хумсалж буй авлигал, хээл хахуулиас сэргийлэх, үүнийг мөрдөн шалгах үүднээс Авлигатай тэмцэх газрыг яаралтай чадваржуулах,
- f) Хандивлах үйл ажиллагааг дэмжих талаар сангуудтай хамтран ажиллаж, гадаадын тусламжаас хамааралтай байдлыг багасгах.

### Мэдээлэл цуглуулах

19. Төрийн мэдээллийн төвийг байгуулан, Засгийн газрын байгууллагууд болон хэрэгжиж байгаа төслүүдийг цахим хуудастай болгосон, мөн хүүхдийн талаар статистик мэдээллийг цуглуулах талаар гаргаж буй зүтгэлийг Хорооноос сайшаан тэмдэглэж байна. Гэвч Хороо дараах зүйлд сэтгэл зовниж буйгаа илэрхийлье:



- a) Хүүхэдтэй холбоотой статистик мэдээлэл цуглуулах, дүгнэлт хийх, илтгэх талаар Үндэсний статистикийн хороо болон бусад Засгийн газрын байгууллагуудын хамтын ажиллагаа дутмаг;
- b) Хүнд нөхцөлд амьдарч буй хүүхдийн талаар нэгтгэж, дүгнэлт хийсэн үндэсний мэдээллийн бааз хангалтгүй, хүүхэд хамгааллын тогтолцоо төдийлөн хөгжөөгүй төвлөрсөн биш байгаа учраас хүүхдийн хамгааллын үндэсний статистик мэдээлэл байхгүй;
- c) Баталгаатай статистик мэдээллийг цуглуулах, боловсруулах, олж авахад бэрхшээл байсаар байгаа.

20. Үндэсний статистикийн хороог хуулиар хүлээсэн өөрийн эрх үүрэг, тэр дундаа салбар хоорондын мэдээлэл цуглуулахад зохицуулалт хийх үүргээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай санхүү, техник, хүний нөөцөөр хангахад Гишүүн улс анхаарлаа хандуулахыг Хорооноос зөвлөж байна. Мөн 18-аас доош насны бүх хүүхдийн талаарх мэдээллийг цуглуулах, одоо байгаа болон шинээр цуглуулах мэдээлэлд дүгнэлт хийж, төрийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийн сайжруулахад ашиглах шинжлэх ухааны нотолгоог бий болгохыг зөвлөж байна.

#### **Конвенцийг түгээх, сурталчлах, мэдээлэл дээшлүүлэх**

21. Мэргэжлийн хүмүүсийг сургалтад хамруулах, олон нийтийн компант ажил өрнүүлэх, Конвенцийг монгол болон казак хэл дээр хөрвүүлж, хэвлэх зэргээр хүүхдийн эрхийн талаар мэдээллийг түгээх тал дээр Гишүүн улсын зүгээс гаргасан хичээл зүтгэлийг хүлээн зөвшөөрч байна. Хэдий тийм ч, ялангуяа хөдөө орон нутаг, алслагдмал аймагт сумдад холбогдох мэргэжлийн хүмүүс, олон нийт, эцэг эх, хүүхдүүдийн дунд конвенцийн талаарх мэдээлэл хангалтгүй байгаад сэтгэл зовниж байна.

22. Конвенцийг түгээх, түүний зарим заалтуудыг зохистой, системтэй сургалтаар олон нийтэд тэр дундаа хүүхэд, эцэг эх, хүүхэдтэй ажилладаг мэргэжилтнүүдэд түгээх, хууль сахиулах албан тушаалтан, Их хурлын гишүүн, шүүгч, хуульч, эрүүл мэндийн ажилтан, багш, сэтгүүлч зэрэг хүүхдийн төлөө болон хүүхэдтэй ажилладаг мэргэжилтнүүдийг хүүхдийн эрхийн талаар ойлголттой болгох тал дээр үйл ажиллагаагаа нэмэгдүүлэх, бэхжүүлэхийг Хороо Гишүүн улсад зөвлөж байна.

#### **Иргэний нийгэмтэй хамтран ажиллах**

23. Гишүүн улсын тайланг бэлтгэхэд зөвлөгөө өгсөн төрийн бус байгууллага болон хүүхдийн төлөөллийн байгууллагуудын оролцоог Хороо талархан хүлээн авч байна. Хэдий тийм ч, конвенцийн хэрэгжилтийн талаар стратеги, бодлого боловсруулах, мониторинг хийхэд ТББ-ийн оролцоо хязгаарлагдмал байгааг тэмдэглэж байна.

24. Конвенцийн хэрэгжилтэд иргэний нийгмийн байгууллагууд чухал үүрэгтэй гэдгийг Хороо цохон тэмдэглэхийн зэрэгцээ бодлого шийдвэрийг боловсронгуй болгох, хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, Хорооноос өгсөн дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэх, дараагийн тайлан илтгэлд бэлтгэх зэргээр ТББ болон хүүхдийн оролцооны байгууллага гэх мэт иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах, тэдний үйл ажиллагааны зохицуулалтыг сайжруулахыг Гишүүн улсад зөвлөж байна.

## **2. Үндсэн зарчим**

*(Конвенцийн 2, 3, 6, 12 дугаар зүйл)*

### **Ялгаварлан гадуурхахгүй байх**

25. Эмзэг бүлгийн хүүхдийг ялгаварлан гадуурхахаас сэргийлэх талаар зарчмын арга хэмжээнүүдийг Гишүүн улс авсан гэдгийг Хороо тэмдэглэж байна. Гэвч, хөвгүүд охидын аль аль нь хүйсээр ялгаварлах байдалд өртөж, цаашлаад угсаа гарал, хөгжлийн бэрхшээл, хүүхдийн гэр бүлийн амьдралын түвшин, амьдарч буй газар нутгаасаа болж хүүхэд ялгаварлалд өртөх (алаг үзэх) явдал байсаар байгаад харамсаж байна. Мөн баруун бүсэд амьдардаг казах зэрэг үндэстний цөөнхийн хүн амын дунд тэгш бус байдал байсаар байгаад сэтгэл зовниж байна.

26. Одоо мөрдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг баталгаажуулах, ялгаварлан гадуурхахгүй байх зарчим нь Конвенцийн 2 дугаар зүйлтэй бүрэн нийцэж буй эсэхийг хянахыг Гишүүн улсад Хороо зөвлөж байна. Мөн хүүхдийн эсрэг ялгаварлан гадуурхах үзэгдлийг нийгмийн бүх салбарт шийдвэрлэж, дээр дурдсан мэдээллүүд, мөн түүнчлэн 2009 онд болсон Дурбаны Чуулга уулзалтын дараа авсан арга хэмжээний талаарх мэдээллийг дараагийн тайлан илтгэлд багтаахыг Гишүүн улсад зөвлөж байна.

### **Хүүхдийн ашиг сонирхлыг дээдлэх**

27. Хүүхдийн ашиг сонирхлыг дээдлэхэд одоо хэрэгжиж буй үндэсний хууль тогтоомж ихээхэн ач холбогдол өгч буйд Хороо талархаж байна. Хэдий тийм ч, бодит амьдрал дээр эдгээр заалтууд нь хангалттай хэмжээнд хэрэгжихгүй байгаад харамсаж байна.

28. Хүүхдийн ашиг сонирхлыг дээдлэх ерөнхий зарчмыг бүх л хуулийн заалтууд төдийгүй, хүүхэд нөлөөлж болохуйц шүүх, засгийн газрын шийдвэр, төсөл хөтөлбөр, үйлчилгээнд зохих байдлаар тусгах талаар тавьж буй хүчин чармайлтаа үргэлжлүүлэн сайжруулахыг Хорооноос гишүүн оронд зөвлөж байна.

### **Хүүхдийн амьд явах, амьдрах, эсэн мэнд хөгжих эрх**

29. Хүүхдийг хамгаалах хууль тогтоомжийг одоогоор тодорхой хэмжээнд бүрдүүлсэн болон хүүхэд бүр аюулгүй тайван, хүчирхийлэлгүй орчинд амьдрах эрхийг хангах механизмыг сайжруулахын тулд Гишүүн улсын авсан арга хэмжээг Хороо талархаж байна. Гэвч 2005 онд Шадар Сайдын гаргасан тушаалыг хэрэгжүүлэх, мөрдөн сахиулах талаар хангалтгүй анхаарснаас унаач хүүхдүүд гэмтэх, амиа алдах зэргээр гэнэтийн ослын хохирогч болсоор байгаа, мөн зам тээврийн осолд орох, морь болон бусад гаршуулсан амьтан унаж байгаад осолдох зэргээр хүүхдүүд хохирох нь нэмэгдсээр байгаад харамсаж байна.

30. 6-р зүйл болон Конвенцийн бусад холбогдох заалтуудын дагуу дараах арга хэмжээг авахыг Гишүүн улсад Хороо зөвлөж байна.

- a) Хүүхэд бүрийн амьд явах эрхийг хамгаалахад бүх хүчин чармайлтаа дайчлах,
- b) Ослоос сэргийлэхтэй холбоотой олон нийтийн дунд мэдээлэл түгээх, компани ажил өрнүүлэх зэргээр олон нийтийн дунд мэдлэг нэмэгдүүлэх хүчин чармайлтаа үргэлжлүүлэн сайжруулах,

- с) Осол гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөрийн эрүүл мэндийн чиглэлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд ихээхэн анхаарах.

#### **Хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх**

31. Гишүүн улс холбогдох хууль тогтоомжиндоо хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх зарчмыг оруулж өгсөн явдлыг Хороо сайшаан тэмдэглэхийн зэрэгцээ бодит байдал дээр энэ зарчим хэрэгжихгүй байгаад харамсаж байна. Мөн түүнчлэн, Хүүхдийн оролцооны үндэсний хөтөлбөрийн (2005) төслийг Улсын их хурлаас одоо болтол батлаагүй явдалд харамсаж байгаагаа илэрхийлж байна.

32. Гишүүн улсын хоёрдугаар тайлангийн дүгнэлт зөвлөмжид өгч байсны нэгэн адилаар гэр, сургууль, орон нутаг, халамж асрамжийн байгууллага, шүүхийн болон захиргааны шийдвэр зэрэг хүүхдэд нөлөөлж буй бүх асуудалд хүүхдийн оролцоог дэмжиж, цаашид хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх зарчмыг сахин, хэрэгжүүлж, дэмжих тал дээр хүчин чармайлт гаргахыг Гишүүн улсад зөвлөж байна. Хүүхдийн оролцооны талаар үндэсний бодлогын төслийг Улсын Их Хурлаас батлах, ингэхдээ Конвенцийн 12–р зүйл болон хүүхдийн үг хэлэх эрхийн тухай Хорооноос гаргасан 12–р ерөнхий тайлбарыг (2009) харгалзан үзэхийг зөвлөж байна.

### **3. Иргэний эрх, эрх чөлөө (Конвенцийн 7, 8, 13–17 болон 37 (а) заалт)**

#### **Төрсний бүртгэл**

33. Гишүүн улсад 2006 оноос хойш төрсний гэрчилгээг үнэ төлбөргүй олгодог болсон явдлыг сайшаан тэмдэглэж байна. Хүүхдийн төрсний бүртгэлийн түвшин өндөр байгаа хэдий ч шинээр төрсөн хүүхдийн 10 орчим хувь нь дотоодын шилжилт хөдөлгөөн, төрсний бүртгэл хөтөлдөг газрын байршил алслагдмал, хүүхдийн төрсний бүртгэлийг хийлгэхийн ач холбогдолын талаар малчин өрхийн мэдээлэл дутмаг зэрэг шалтгааны улмаас төрсний бүртгэл хийлгээгүй байна.

34. Төрсний бүртгэлд хоцорч хамрагдаж буй хүүхдийг үнэ төлбөргүй бүртгүүлэх боломжоор хангах зэргээр бүх хүүхдийн төрсний бүртгэлд хамруулах, ингэхдээ алслагдмал аймаг, малчин өрхөд илүү анхаарал хандуулах тал дээр хүчин чармайлтаа сайжруулж ажиллахыг Гишүүн улсад Хороо зөвлөж байна.

#### **Зохистой мэдээлэл олж авах, хүртэх**

35. Хэдийгээр Гишүүн улс олон нийтийн телевиз, радиогоор үндэсний цөөнхид зориулсан хөтөлбөрийг дэмжиж, мэдээллийн технологийн хүртээмжийг сайжруулсан явдлыг Хороо талархаж буй ч зарим хөтөлбөрүүдийг хүүхдийн хөгжлийн болон боловсролын хэрэгцээнд нийцсэн, хүүхдийн насанд мэдээллийн агуулга нь тохирсон байдлаар шинэчлэх хэрэгцээ байгааг сануулья.

36. Гишүүн улсад Хороо дараах зүйлүүдийг зөвлөж байна.

- а) Бүх хүүхдэд, тэр дундаа алслагдмал аймаг, хөдөө орон нутагт амьдардаг хүүхдүүд өөрийн нас, хэрэгцээнд тохирсон зохих мэдээллийг эрх тэгш хүртэх боломжийг хангахад чиглэсэн хүчин чармайлтаа сайжруулах

- b) Зохистой мэдээллийг хүртэх боломжоор хүүхдийг бүрэн хангахаас гадна хүүхдэд хортой мэдээллээс хүүхдийг хамгаалах тал дээр зохих зөвлөмжийг боловсруулах. “Хүүхэд болон хэвлэл мэдээлэл” гэсэн сэдвээр хийсэн ерөнхий хэлэлцүүлгээс баталсан Хорооны зөвлөмжийг (CRC/C/57, 242–257 дугаар заалт, 1996) дагаж мөрдөхийг Оролцогч оронд зөвлөж байна.

### **Бие махбодын шийтгэл**

37. Боловсролын орчинд бие махбодын шийтгэлийн асуудлыг шийдвэрлэхэд хүчин чармайлт гаргасан явдлыг Хороо талархан тэмдэглэж байна. Гэвч хүүхдийн амьдралын бүх хүрээнд бие махбодын шийтгэл өргөн хүрээнд хэрэглэгдсээр байгаад харамсаж байгаагаа дахин илэрхийлье.

38. Гэр бүл болон хүүхдийн халамж, асрамжийн үйлчилгээний тогтолцоо зэрэг бүх орчинд бие махбодын шийтгэлийн аль ч хэлбэрийг хүүхдийн хүмүүжлийн арга болгож хэрэглэх явдлыг зогсоох, урьдчилан сэргийлэх талаар Гишүүн улс хууль тогтоомж батлаж хэрэгжүүлэхийг Хорооноос зөвлөж байна. Цаашлаад Гишүүн улс Конвенц, тэр дундаа 28–р зүйл, мөн Хүүхдийг бие махбодын шийтгэл болон бусад харгис, хүнлэг бус шийтгэлээс хамгаалах талаар гаргасан Хорооны 8–р ерөнхий тайлбарыг (CRC/GC/2006/8, 2006) харгалзан үзэж бие махбодийн шийтгэлийн талаарх олон нийтийн хандлагыг өөрчлөх, хүүхдийн эрхэмсэг оршихуйн эрхийг хүндэтгэх, хүмүүжлийн бусад арга барилыг хэрэглэх тал дээр хүүхдүүдийг оролцуулан олон нийтэд боловсрол олгох, мэдээлэл өгөх, нийгмийг дайчлах компани ажлыг зохион байгуулахыг Хороо зөвлөж байна.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх Нэгдсэн Үндэстний Байгууллагын судалгааны дараа авсан арга хэмжээ

39. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргын судалгаан дээр үндэслэн, Гишүүн улсад Хороо дараах зүйлүүдийг зөвлөж байна.

- a) 2005 оны 6 дугаар сарын 14–16–нд Банкгокт болсон Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар Зүүн Ази Номхон далайн бүсийн зөвлөгөөнөөс гарсан үр дүн, зөвлөмжийг харгалзан үзэхийн хамт хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх НҮБ–ын бие даасан зөвлөхүүдийн судалгааны тайланд багтсан зөвлөмжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авах,
- b) Хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг устгахаар хийсэн судалгааны хэрэгжилтийг голлон анхаарах. Ингэхдээ дараах зөвлөмжүүдэд тусгай анхаарал хандуулах:
- Хүүхдийг эсрэг хүчирхийллийн бүх төрлийг хориглох
  - Хүчирхийллийн бус үнэлэмжийг сурталчилж, мэдлэг дээшлүүлэх
  - Хүүхдийн эсрэг хүчирхийллийн жендерийн асуудлыг шийдвэрлэх
- c) Хүүхэд бүрийг бүх төрлийн бие махбод, сэтгэл санаа болон бэлгийн хүчирхийллээс хамгаалах, ийм төрлийн хүчирхийллээс бодитоор сэргийлж, богино хугацаанд хариу үйлдэл хийх тогтолцоог бий болгоход иргэний нийгэм тэр дундаа хүүхдийг оролцоотой хамтын арга хэмжээ авахдаа эдгээр зөвлөмжийг ашиглах,

- d) Дараагийн тайлан илтгэлдээ Хүүхдийн эсрэг хүчирхийллийн судалгаанаас Гишүүн улсад өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн талаар мэдээллийг оруулах,
- e) Дээрх зорилгоор Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар Ерөнхий нарийн бичгийн даргын тусгай төлөөлөгч, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүний эрхийн дээд комиссар болон Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас техникийн тусламж авах.

**4. Гэр бүлийн орчин ба асран хамгаалалт (Конвенцийн 5; 18 (1–2 дугаар заалт); 9–11; 19–21; 25; 27 (4 дүгээр заалт); болон 39 дүгээр зүйлүүд)**

**Гэр бүлийн орчин**

40. Хүүхэд хүмүүжүүлэх чадварыг бэхжүүлэх, өөрөө сурах бичиг, гарын авлага боловсруулах, нийгмийн суурь халамжаар хангах зэргээр эцэг эхчүүдийг хүүхдээ өсгөхөд мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлэх талаар Гишүүн улс хичээл зүтгэл гарган ажиллаж байгааг Хороо талархан хүлээн авч байна. Гэвч 2006 оноос хойш гэр бүлийн хуулийг эргэн харах талаар ямар ч шийдвэр гараагүйд харамсаж, өрх толгойлсон эхчүүд, эцэг эх нь гадаадад гарснаас болж үлдсэн хүүхэд, түр хугацаанд гэр бүлээ толгойлж буй хүүхэд зэрэг эцэг эхийн хараа хяналтаас гадуурх хүүхдийн өөр шинэ бүлэг бий болж байгаад сэтгэл зовниж байна.

41. Хүчирхийллийн бус, хүмүүжлийн зэрэг арга барилыг сурталчлах бодлого журам, сургалтын хөтөлбөрийг боловсруулж, эцэг эх, гэр бүлд хэрэгцээтэй үед нь шаардлагатай дэмжлэгийг аль болох өргөн хүрээнд өгөх талаар 2005 онд өгсөн зөвлөмжөө Хороо дахин илэрхийлж байна. Мөн Хороо дараахь зүйлийг Гишүүн улсад зөвлөж байна.

- a) Хүүхдийн эрхийг хангах чиглэлээр мэргэшсэн нийгмийн ажилтан зэрэг зохих мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан гэр бүлийг дэмжих төвүүдийг хороо, сум, орон нутагт байгуулах,
- b) Гэр бүлийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг батлах,
- c) Хүүхдэд эцгийн хариуцлагын мөнгөн тэтгэмж төлөх ёстой хүмүүс төлбөрөө өгч буй эсэхэд болон хүүхэд тэжээн тэтгэгчээс мөнгөн тэтгэмжээ хүртэж чадаж буй эсэхэд анхаарал хандуулах,
- d) Хүүхдийн эрхийг хангах чиглэлээр нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээг нэвтрүүлэх, ийм үйлчилгээг хүүхэд, гэр бүлд үр дүнтэй хүргэх хууль эрх зүйн орчин бүрдүүлэх, тогтолцоог сайжруулахын зэрэгцээ нийгмийн ажилтны ажлын гүйцэтгэлийг хянах дүрэм журмыг бий болгох.

**Гэр бүлийн орчноос хөндийрсөн хүүхэд**

42. Гэр бүлийн орчноос хөндийрсөн хүүхдэд зориулсан хувилбарт халамжийн үйлчилгээг нэвтрүүлэх, халамж асрамжийн газар, ажилтнуудын үзүүлж буй асрамжийн үйлчилгээний наад захын стандартыг тогтоох, садан төрлийн асрамж болон асралт гэр бүлийн үйлчилгээг нэвтрүүлэхийн тулд Гишүүн улсын зүгээс авсан алхмуудыг Хороо сайшааж байна. Гэвч хүүхдийн асрамжийн газарт системтэй хяналт дутмаг байгаа, хүүхдийг асрамж халамжийн газарт илгээсний дараа кейс менежементийн үйлчилгээ

үзүүлэх, хянах тогтолцоо бүрдээгүй, төвлөрүүлэн халамжлахаас өөр хувилбарт халамжийн үйлчилгээ үзүүлж болохуйц хүүхдийн халамжийн зохицуулалтыг үндэсний хэмжээнд системтэйгээр шийдсэн байдал дутмаг байгаад Хороо харамсаж байна.

43. Хороо Гишүүн улсад дараах зүйлийг зөвлөж байна.

- a) Эмзэг бүлгийн гэр бүлүүдэд дэмжлэг, зөвлөмж өгөх, мэдлэг дээшлүүлэх компани ажлыг зохион явуулах замаар хүүхдийг төвлөрүүлэн халамжлах газар байршуулахаас сэргийлэх хөтөлбөр, бодлого журмыг боловсруулах,
- b) Төвлөрүүлэн халамжлах газарт буй хүүхдийг гэр бүлтэй нь эргэн нэгтгэх шаардлагатай бүх арга замыг авч хэрэгжүүлэх,
- c) Конвенцийн 25–р зүйлд заасны дагуу, төвлөрүүлэн халамжлах газарт байршиж буй хүүхдийн байдлыг цаг тухай бүр хянах цогц механизмыг бүрдүүлж, шаардлагатай санхүү болон хүний нөөцөөр хангах, тэднээр ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх,
- d) 2009 оны 11 дүгээр сарын 20–ны өдөр НҮБ–ын Ерөнхий Ассамблейн тогтоолоор батлагдсан Хүүхдэд үзүүлэх халамжийн хувилбарт үйлчилгээний зааврыг A/RES/64/142 мөрдөх.

### **Үрчлэлт**

44. Дотоод болон гадаад үрчлэлтийг зохицуулах эрх зүйн актыг сайшааж буй ч, Гаагийн Конвенцийг хэрэгжүүлэх үүрэгтэй байгууллагын талаар мэдээлэл дутмаг, хүүхэд үрчлэх хүсэлтэй эцэг эхэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ байхгүй, үрчлэлтийн дараа хяналт тавих, шалгалт хийх болон дотоод үрчлэлтийн үйл явцад хүүхдийн үзэл бодлыг харгалзан үзэх механизм бүрдээгүй байгаад харамсаж байна. Мөн гадаад үрчлэлтийн үйл явц нь Улс хоорондын үрчлэлтийн талаар хамтран ажиллах хүүхдийг хамгаалах Гаагийн Конвенцтэй бүрэн уялдахгүй байгаад сэтгэл зовниж байна.

45. Асралт гэр бүл болон үрчлэлтийн асуудлыг зохицуулдаг үндэсний хэмжээний цогц, бодлого, заавар бий болгох, үүнтэй холбоотой хяналт, төвлөрсөн хяналт шалгалтын механизмыг бүрдүүлэх тухай тухай өмнөх зөвлөмжөө (2005, 36 дүгээр бүлэг) Хороо Гишүүн улсад дахин сануулж байна. Мөн хүүхдийн эрх ашгийг дээдэлсний үндсэн дээр дотоодын болон улс хоорондын үрчлэлтийг зохицуулдаг дүрэм журмыг Конвенцийн 21–р зүйлийн заалтууд болон Гаагийн конвенцтэй уялдуулахыг зөвлөж байна. Цаашлаад, Гишүүн улс холбогдох институтыг, тэр дундаа Гаагийн конвенцийн хэрэгжилтийг хангах чадвар, бүрэн эрх бүхий үндэсний газрыг байгуулахыг санал болгож байна.

### **Хүчирхийлэл, үл хайхрах байдал**

46. Хэдийгээр хүүхдийг үл хайхрах байдал, хүчирхийллээс сэргийлж, үүнтэй тэмцэх талаар Гишүүн улсын авсан арга хэмжээг үнэлж байгаа ч, хүүхдийг хамгаалах цогц стратеги байхгүй байгаад сэтгэл зовниж байна. Мөн хүүхэд тэр дундаа охид хүчирхийлэлд өртсөөр байгаа, хүчин, ураг төрлийн хүчингээс сэргийлэх талаар одоо мөрдөж буй хууль эрх зүйн заалтыг сахиулах явдал хангалтгүй, эрэгтэй, эмэгтэй хүүхдийн эсрэг үйлдсэн хүчингийн гэмт хэргийн шийтгэл ялгаатай байгаа, бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон хүүхдүүдэд хамгаалал, нөхөн сэргээх тусламж хангалттай хүрдэггүй,

харин ч эсрэгээрээ тэднийг гэмт хэргийн буруутан мэтээр үзэх явдал байгаад харамсаж байна. Цаашлаад ураг төрлийн хүчин үйлдсэн этгээдийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу яллан шийтгэхгүй байгаад харамсаж байна.

47. Гишүүн улсыг дараах зүйлүүдийг хэрэгжүүлэхийг Хороо шаардаж байна.

- a) Гэр бүл дэх хүүхдийн хүчирхийллийн бүх хэлбэрийг хориглож, хүчин, ураг төрлийн хүчингийн хэрэгт ноогдуулдаг ял шийтгэлийг хэрэгжүүлэх
- b) Хүүхдийн эсрэг хүчирхийлэл гарахад хүргэж байгаа шалтгааныг илрүүлж шийдвэрлэх, хүүхдэд хор хохирол учрахаас сэргийлэх, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, албадлага, хүүхдийг үл хайхрахаас урьдчилан сэргийлж, хариу үйлдэл хийхийн тулд үндэсний хэмжээний суурь судалгаа хийж, үүнээс гарсан мэдээлэл дээрээ үндэслэн хүчирхийллийн хохирогч болсон хүүхдийг хамгаалж, нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах үндэсний тогтолцоог бий болгох.
- c) Гэр бүл болон төвлөрсөн үйлчилгээ үзүүлдэг газруудад гарсан хүүхдийн эсрэг бие махбод, бэлгийн хүчирхийлэл, үл хайхрах байдлын кейсийн тоо болон хамрах хүрээнд хяналт тавих механизмыг бататгаж, эдгээр механизмуудын хоорондын зохицуулалтыг сайжруулах,
- d) Хүүхдийн хүчирхийллийг бүртгэж авах механизмийг бий болгох
- e) Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй хүүхдийн кейсийг бүртгэх, зохих арга хэмжээг авах үүргийн талаар хүүхэдтэй ажилладаг бүх мэргэжилтнүүдийг сургалтанд хамруулах,
- f) Хүүхдийн хүчирхийлэл, үл хайхрах байдлаас сэргийлэхтэй холбоотой мэдээллийг түгээх олон нийтийн мэдлэг дээшлүүлэх компаниг ажлыг өрнүүлэх, эцэг эхийг заавар зөвлөмжөөр хангах;
- g) Бүх аймгуудад хүүхэд, гэр бүлд зориулсан үнэгүй сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төвийг бий болгож хүчирхийлэл, үл хайхрах байдлын хохирогч болсон охид хөвгүүдийг нөхөн сэргээх үйлчилгээ, зөвлөмж, дэмжлэг, бусад үйлчилгээг эрх тэгш байдлаар хүртэх боломжоор хангах.

5. Эрүүл мэнд ба нийгмийн халамж (Конвенцийн. 6; 18 (3 дугаар заалт); 23; 24; 26; зүйлүүд болон 27 дугаар зүйлийн 1–3 дугаар заалт)

### **Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд**

48. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлаар Гишүүн орны зүгээс гаргасан хичээл зүтгэлийг Хороо үнэлж байгаа ч гэсэн, тэдгээр хүүхдүүд олон асуудалтай тулгарсаар байгаад харамсаж байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх зүйн тодорхойлолт нь хэтэрхий өргөн хүрээг хамарсан байгаа бөгөөд эдгээр хууль тогтоомжийн зөрүүтэй заалууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст сөргөөр нөлөөлж болохоор байна. Цаашлаад, боловсрол, нийгмийн халамж, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж дутмаг, тэдэнд зориулсан зохистой дэд бүтэц байхгүйгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нийгмийн үйлчилгээнээс хаягдаж үлдэж байгаад гүнээ сэтгэл зовниж байна. Ерөнхийдөө, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нь “эрхэмсэг оршихуйн эрхийг нь дээдэлсэн, бие даасан байдал, оролцоог нь дэмжсэн нөхцөлд сайн сайхан, бүрэн дүүрэн амьдрах” эрхээ эдлэхэд бэрхшээлтэй байгааг Хороо тэмдэглэж байна.

49. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хамгаалж, сахиулахад авч буй арга хэмжээгээ үргэлжлүүлэн сайжруулж, ингэхдээ Конвенцийн 23 дугаар зүйл болон Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар ерөнхий тайлбарыг Гишүүн улс дагаж мөрдөхийг Хороо зөвлөж байна. Тухайлбал:

- a) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар бодитой нарийвчилсан статистик мэдээллийг үндэсний болон орон нутгийн хэмжээнд цуглуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн мэдээллийн санг бий болгох,
- b) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан үндэсний хэмжээний цогц бодлогыг боловсруулах,
- c) мэргэжлийн сургалтанд хамрагдах зэрэг боловсрол эзэмших эрхээ аль болох өргөн хүрээнд эдлэх боломжийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд олгох,
- d) Үндэсний болон орон нутгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлийн талаар мэргэшсэн мэргэжилтэн болон санхүүгийн нөөц бололцоогоор хангах, гэр бүлийг дэмжих бүлэг болон мэргэжилтнүүдэд зориулсан сургалт зохион байгуулах зэргээр олон нийтийн оролцоонд түшиглэсэн нөхөн сэргээх хөтөлбөрийг дэмжин өргөжүүлэх тал дээр томоохон алхмуудыг авах,
- e) Хөгжлийн бэрхшээлтэй нярай хүүхэд болон цэцэрлэгийн насны хүүхдийг эрт илрүүлж, интервенцэд хамруулах үйлчилгээг бий болгох. Ингэхдээ гэр бүлийн дэмжлэг, орон нутгийн оролцоонд тусгай анхаарал хандуулах,
- f) Хүүхэд, эцэг эх, гэр бүл, асран хамгаалагч, орон нутгийн иргэдийн дунд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ялгаварлахгүйгээр зөвөөр ойлгох байдлыг уриалах үүднээс олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх санаачлагуудыг хэрэгжүүлэх.

#### **Эрүүл мэнд болон эрүүл мэндийн үйлчилгээ**

50. Гишүүн улсын зүгээс эрүүл мэндийн салбарт авсан олон арга хэмжээг үнэлж, нярайн болон хүүхдийн эндэгдэл багассаныг тэмдэглэж байгаа хэдий ч, хүүхдүүд тэр дундаа 5–аас доош насны хөвгүүдэд эрдэс бодис болон шим тэжээлийн ноцтой дутагдлаас болж өсөлт зогсох, сульдаа тусах явдал байсаар байгаад сэтгэл зовниж байна. Мөн эрүүл мэндийн төсвийн ихэнх нь дэд бүтэц, биеийн эрүүл мэндийн салбарт зарцуулагдаж архи, хар тамхи хэрэглэж буй хүүхдүүдэд зориулсан үйлчилгээ зэрэг сэтгэцийн эрүүл мэндтэй холбоотой нийгмийн эрүүл мэндийн дэмжлэг үзүүлэх чиглэлийг хөгжүүлэхэд анхаарахгүй байгаад сэтгэл зовниж байна.

51. Хороо Гишүүн улсад дараах зүйлийг зөвлөж байна.

- a) Анхан шатны тусламжийн үйлчилгээнд гол анхаарлаа хандуулах, эмзэг бүлгийн гэр бүлийн хэрэгцээг шийдвэрлэх, хүүхдийн эрүүл мэндийг тодорхойлдог нийгмийн хүчин зүйлүүдийг тогтооход ашиглаж байгаа нийгмийн эрүүл мэндийн орчин үеийн хандлагуудыг нэвтрүүлэх зэргээр эрүүл мэндийн хамгийн өндөр стандартыг хангасан үйлчилгээг хүүхэд бүр хүртэж байхыг баталгаажуулсан эрүүлийг хамгаалах тогтолцоог хөгжүүлэх,
- b) Эхийн болон хүүхдийн эрүүл мэндийг хариуцсан Засгийн газрын байгууллагыг байгуулж уг байгууллагыг орон нутагт бэхжүүлэх талаар анхаарах,



- с) Конвенцийн 24 (с) зүйлийн дагуу ундны цэвэр усны хүртээмжийг нэмэгдүүлэх болон ариун цэврийг сайжруулах арга хэмжээг бэхжүүлэх,
- д) Жирэмсэн эхчүүдийг хамгаалах Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 183 конвенцийг (2000) соёрхон батлах.

52. Цаашлаад хүүхдийн эрүүл мэнд, шим тэжээл, хөхөөр хооллохын давуу тал, витаминжуулалт болон Витамин А болон төмрийн бэлдмэл, эрдэс бодис, ариун цэвэр, орчны ариун цэвэр, нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх суурь мэдээллийг эцэг эх, асран хамгаалагч нарт өгөх компани т ажил өрнүүлэх, олон нийтийн оролцоонд түшиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх замаар Гишүүн улсад өндөр түвшинтэй байгаа хүүхдийн тэжээлийн дутагдлыг аль болох хурдан хугацаанд шийдвэрлэхийг зөвлөж байна.

### **Өсвөр үеийн эрүүл мэнд**

53. Аймгийн төвүүд болон Улаанбаатар хотод өсвөр үеийнхэнд ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг загвар байгууллага байгуулах талаар Гишүүн улсын гаргасан хүчин чармайлтыг Хорооноос үнэлж байна. Мөн ДОХ-той тэмцэх үндэсний хороог дахин байгуулсан явдлыг талархан тэмдэглэж байгаагаа илэрхийлье. Гэвч өсвөр үеийнхийн эрүүл мэндийн талаар нарийвчилсан задаргаа бүхий тоо баримт, нөхөн үржихүйн эрүүл мэнд болон өсвөр насныханд чиглэсэн одоогоор хэрэгжиж буй эрүүл мэндийн үйлчилгээний талаар мэдээлэл хангалтгүй байгаад харамсаж байна.

54. Гишүүн улсад Хороо дараах зүйлүүдийг зөвлөж байна.

а) Өсвөр насны хүүхдийг бүрэн хэмжээнд оролцуулан өсвөр насны хүүхдийн эрүүл мэндийн асуудлын мөн чанар, хамрах хүрээг ойлгох үүднээс цогц судалгаа явуулах, үүн дээрээ үндэслэн өсвөр насны хүүхдийн эрүүл мэндийн бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулах,

б) Конвенцийн агуулгын хүрээнд өсвөр насны хүүхдийн эрүүл мэнд болон хөгжлийн талаар гаргасан Хорооны ерөнхий зөвлөмж 4-тэй уялдуулан бэлгийн харилцаа болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар сургуулиар дамжуулан боловсрол олгох, өсвөр үеийнхэнд мэдрэмжтэй, нэргүй зөвлөгөө өгөх зэргээр нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээг бүх өсвөр насны хүүхдэд хүртээмжтэй болгох.

### **Сэтгэцийн эрүүл мэнд**

55. Өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэх тал дээр Гишүүн улс хүч чармайлт гаргасан явдлыг Хороо сайшаан тэмдэглэж байна. Гэвч хүүхдүүд, ялангуяа хот суурин газрын хүүхдүүд бухимдал, сэтгэлийн дарамт, архи тамхинд донтох, зан авирын доголдолд өртөх байдал ихэссэн, эдгээр нийгмийн эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэх, урьдчилан сэргийлэх үр дүнтэй интервенц дутмаг байгаад хороо харамсаж байна. Мөн Гишүүн улсад хүүхэд, ялангуяа охидын дунд амиа хорлох байдал гарч байгаад хороо их сэтгэл зовниж байна.

56. ДЭМБ-ын үндсэн зөвлөмжийн заавал хэрэгжүүлэх ёстой зөвлөгөөтэй уялдуулан анхан шатны эмнэлгийн байгууллага, сургууль, орон нутгийн хэмжээнд сэтгэцийн эрүүл мэндийг сурталчлах, зөвлөгөө өгөх, сэтгэцийн эрүүл мэндийн эмгэгээс урьдчилан

сэргийлэх, сэтгэцийн ноцтой эмгэг бүхий хүүхэд өсвөр насныханд тэднийг ялгаварлалд оруулалгүйгээр эмнэлэгт болон гэрээр сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх зэрэг үйлчилгээг багтаасан хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний хэмжээний цогц бодлогыг боловсруулахыг Хороо Гишүүн улсад зөвлөж байна. Мөн бага сургууль болон дотуур байранд анх орж буй хүүхдийн танин мэдэхүй, нийгэм, сэтгэл санааны хөгжлийн хэрэгцээг хангах үүднээс тэдэнд тусламж үзүүлэхийг Гишүүн улсад зөвлөж байна.

### **Амьдралын түвшин**

57. Гишүүн орны ядуурал газар авч, бүс нутгийн хооронд амьдралын түвшин ялгаатай байгаад сэтгэл зовниж байгаагаа илэрхийлье. Мөн хот хөдөөгийн амьдралын нөхцөл, орчинд тэгш бус байдал их байгаад хамгийн их сэтгэл зовниж байна. Орлоготой холбоотой үзүүлэлтээр хэмжиж үзэхэд ихэнх хүүхдүүдийн амьдралын ерөнхий түвшин их доогуур байгаагийн зэрэгцээ хоол хүнс, орон байр, боловсрол, ундны усны хүртээмж ариун цэвэр, аюулгүй байдлын баталгаа мөн доогуур байна. Мөн хотын гэр хороололд амьдарч буй хүүхдийн нөхцөл байдал муу, гэрт түүхий нүүрс шатааж дулааны асуудлаа шийдсэнээс болж хүүхдийн эрүүл мэндэд учирч буй сөрөг нөлөөлөлд сэтгэл зовниж буйгаа тэмдэглэе.

58. Хүүхдийн амьдралын түвшинг дээшлүүлэх талаар арга хэмжээ авч ингэхдээ хоол хүнс, ундны усны хүртээмж, ариун цэвэр, эрүүл ахуй, орон байр болон боловсролын чанарыг сайжруулахад голлон анхаарахыг Хорооноос Гишүүн оронд зөвлөж байна. Бүс нутаг хоорондын ялгаатай байдлыг багасгаж, гэрийг халаах өөр арга олох тал дээр Гишүүн орон яаралтай арга хэмжээ авахыг зөвлөж байна.

## **6. Боловсрол, чөлөөт цаг, соёлын арга хэмжээ**

*(Конвенцийн 28, 29, 31 дүгээр зүйл)*

### **Мэргэжлийн боловсрол, зөвлөгөө**

59. Хүүхдэд үнэ төлбөргүй, албан ёсны боловсрол олгож, дотуур байрны зардлыг даахад Гишүүн орны оруулсан хөрөнгө оруулалтыг Хороо үнэлж байна. Сургуулиудыг хүүхдэд ээлтэй болгох тал дээр хүч чармайлт гаргасан явдлыг сайшаан тэмдэглэж байна. Мөн хүүхдэд зориулсан үйлчилгээний хүртээмжид нийгмийн ажилтны үүрэг роль маш чухлыг хүлээн зөвшөөрч боловсролын салбар дахь нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолтод хүүхдийн хамгааллын үүргийг нь оруулж өгсөн явдалд талархаж буйгаа илэрхийлж байна. Гэвч гэр бүл дэх эрэгтэй хүүхдийн үүргийн талаар соёлын чиг хандлагаас болж тэд сургууль завсардсаны улмаас, боловсрол эзэмших хөвгүүдийн тоо цөөрч байгаад харамсаж буйг илэрхийлье. Боловсролын байгууллагад бие махбодын шийтгэл, сэтгэл зүйн дарамт байсаар байгаад сэтгэл зовниж байна. Цаашлаад, алслагдсан, тархаж суурьшсан орон нутагт амьдарч буй, хотод шилжин нүүж ирсэн болон албан бусаар уул уурхайн олборлолт эрхэлж буй гэр бүлийн хүүхдүүд зэрэг зарим хүүхдэд боловсролын үйлчилгээ, тэр дундаа сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ хязгаарлагдмал байгаад Хороо сэтгэл зовниж байна. Мөн сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ муу, тавилга, бие засах газар, аюулгүй байдлыг хангах зэрэг материаллаг хангамж

дутагдалтай байгаад сэтгэл зовниж байна. Хэдийгээр дотуур байрууд малчдын хүүхдийн хэрэгцээг хангаж байгаа ч эдгээр хүүхдүүдийн гэр бүлтэйгээ холбоотой байх явдал хязгаарлагдмал байгаад харамсаж байна.

60. Конвенцийн 28–р зүйл болон бусад холбогдох заалт болон Боловсролыг сайжруулах талаарх 1 дүгээр ерөнхий тайлбарыг харгалзан үзсэний үндсэн дээр Гишүүн улсад Хороо дараах зүйлүүдийг зөвлөж байна.

- a) Боловсролын салбар дахь хүйсийн болон бүс нутгийн ялгаатай байдлыг шийдвэрлэж, сургуулиас завсардсан болон гэр орны ажилд оролцох зэрэг ажил, сургуулиа зохицуулах шаардлагатай хүүхдүүдэд зориулсан магадлан итгэмжлэгдсэн албан бус сургалтын хөтөлбөрийг боловсруулах,
- b) Боломжтой бүх үед хүүхдийг гэр бүлтэйгээ холбоотой байх хэрэгцээ болон үндэсний соёлыг харгалзан үзсний үндсэн дээр малчин өрхийн хүүхдүүдэд зориулсан дотуур байрын чанар, хүртээмжийг үргэлжлүүлэн сайжруулах,
- c) Сургууль болон багш нарын ажлын гүйцэтгэлийн үнэлэхдээ хүүхдэд ээлтэй сургуулийн стандартыг боловсруулж хэрэглэх,
- d) Явуулын сургууль болон интернетээр сургах зэрэг шинэ арга барилаар дамжуулан боловсрол олгоход үргэлжлүүлэн хүч чармайлт гаргах,
- e) Олон нийтэд суурилсан үйлчилгээг хүүхэд гэр бүлд үзүүлэх, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх, зөвлөгөө өгөх үйлчилгээг хүүхдэд хүргэх зэрэг шинэ үүргээ хэрэгжүүлэхэд нь нийгмийн ажилтанд туслах зорилгоор тэдэнд зориулж төсөв хөрөнгийг, хангалттай хуваарилж, тэднийг сургалтанд хамруулах, дэмжлэг үзүүлэхэд онцгой анхаарах,
- f) Багш зэрэг хүүхэдтэй ажилладаг мэргэжилтний хүүхдэд хандах хандлагыг өөрчлөх, тэдэнд болон эцэг эх, хүүхэд, нийт хүн амын дунд хүүхдийн эрхийн талаарх ойлголтыг сайжруулах, хүчирхийллийн бус эерэг хүмүүжлийн арга барилыг сурталчлах, сэтгэл санааны хүчирхийллийн талаар ойлголтыг дээшлүүлэх,
- g) Энэхүү конвенц болон хүүхэдтэй холбоотой бусад хүний эрхийн гэрээ хэлэлцээр зэргийг багтаан хүний эрхийн талаарх сургалтыг сургуулийн хичээлийн хөтөлбөрт оруулах, 2005 оны 7 дугаар сарын 14–д Нэгдсэн Үндэстний Байгууллагын бүх гишүүн улсуудын баталсан Хүний Эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн эхний шатны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авах.

#### **Чөлөөт цаг, амралт, соёлын арга хэмжээнүүд**

61. Хүүхдүүд спорт, урлаг болон бусад чөлөөт цагийн үйл ажиллагаанд оролцож болох газар дутмаг, хүүхэд өсвөр үеийнхэн уулзалт хийж, цугларан, амралт чөлөөт цагийн арга хэмжээнд оролцох газар хомс байгаад Хороо сэтгэл зовниж байгаагаа илэрхийлж байна.

62. Хороо Гишүүн улсыг хүүхдэд ээлтэй газруудыг байгуулж, дараах зүйлийг хийхийг уриалж байна.

- a) Олон нийт, сургууль, хүүхдийн байгууллага болон бусад орон нутгийн нөөц

- бололцоог ашиглан хороо, сумдад хүүхдийн тоглоомын талбай, хүүхэд залуучуудын төвийг байгуулах,
- b) Гэр бүлээрээ чөлөөт цагаа өнгөрүүлэх боломжтой газрын тоог ихэсгэх.

**7. Онцгой хамгааллын арга хэмжээ** (Конвенцийн 22; 30; 38; 39; 40; 37 (b)–(d); 32–36 дугаар зүйлүүд)

**Орогнол хүсэгч болон дүрвэгч хүүхдүүд**

63. Дүрвэгчийн статустай холбоотой 1951 оны Конвенц болон түүний 1967 оны протоколд нэгдэн орох Гишүүн улсын эрмэлзлийг Хороо үнэлж байгаа ч гэсэн, үүнийг ажил хэрэг болгоход авсан алхмууд удаан байгаад сэтгэл зовниж байна. Шилжин нүүгч, дүрвэгч, орогнол хүсэгчдийн хүүхдүүдийн талаар мэдээлэл байхгүй байгаад Хороо харамсаж байна.

64. Дүрвэгчийн статусийн тухай 1951 оны Конвенц болон түүний 1967 оны нэмэлт протоколыг соёрхон батлахыг Хороо Гишүүн улсад дахин (2005, 57 заалт) зөвлөж байна. Цаашлаад, Конвенцийн 22–р зүйл болон бусад холбогдох заалтыг харгалзан үзсэний үндсэн дээр Гишүүн улсад буй орогнол хайгч, дүрвэгч хүүхдүүдийг хамгаалж, халамжлах мөн түүнчлэн тэдэнд эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ, боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авахыг Гишүүн улсад Хороо зөвлөж байна. Цогц бодлого боловсруулахад хөтөч болохуйц нарийвчилсан тоо баримтыг авахын тулд орогнол хүсэгч болон дүрвэгч хүүхдүүдийн талаарх мэдээллийн сан байгуулахыг зөвлөж байна. Цагаач ажилчид болон тэдний гэр бүлийнхний эрхийн конвенцийг соёрхон батлахыг мөн зөвлөж байна.

**Хүүхдийн хөдөлмөр зэрэг эдийн засгийн мөлжлөг**

65. Зарим нэг дотоодын хууль тогтоомж, тэр дундаа албан боловсрол болон ажил эрхлэх насны доод хязгаарыг заасан хууль тогтоомж нь хоорондоо зөрөлдөж байгаа талаар өмнөх дүгнэлт зөвлөмждөө дурдаж байснаа дахин давтаж байна. Мөн тайлангийн хугацаанд хүүхдийн хөдөлмөр эрхлэлт тэр дундаа хүнд хортой хөдөлмөр эрхлэлт өссөн явдалд санаа зовниж байна. Цаашлаад, хүүхдүүд хөдөө аж ахуй, уул уурхайн салбар, цирк зэрэг газарт ажиллан сургуулиас завсардаж байгаа, хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт өртөх, алт угаахад ашигладаг химийн бодист хордох, ажлын байран дээр бэртэж гэмтэх явдал их байхад тэдэнд хүрч буй нийгмийн үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал байгаад харамсаж байгаагаа илэрхийлье.

66. Хүүхдийн хөдөлмөрийн сөрөг үр дүнг шийдвэрлэж, хянах тал дээр яаралтай арга хэмжээ авахыг Хороо Гишүүн улсад зөвлөж байна.

- a) Хүүхдийн хөдөлмөрийн хортой хүнд хэлбэртэй тэмцэх
- b) Энэхүү конвенц болон Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын холбогдох конвенцүүдтэй зөрчилдөж буй хууль тогтоомжуудад шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг хийх,
- c) Хүүхдийн хөдөлмөрийн сөрөг үр дагаврын талаар мэдээлэл олгох компани ажлыг зохион явуулах,

- d) Хөдөлмөр эрхэлдэг бага насны хүүхдүүдийг албан бус сургалт, том хүүхдүүдийг чадваржуулах сургалтад хамруулах,
- e) НҮБ-ын Хүүхдийн Сан, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас техникийн тусламж үргэлжлүүлэн авах.

**Гудамжны нөхцөлд байгаа хүүхдүүд**

67. Хүүхдийг гудамжинд гарч амьдрахаас сэргийлэх талаар Гишүүн улсын зүгээс хэрэгжүүлсэн хүчин чармайлтыг үнэлэхийн зэрэгцээ, хот, суурин газар шинээр бий болж буй гэр хорооллын хүүхдүүдээр гудамжны хүүхдүүдийн тоо өсөж байгаад сэтгэл зовниж байна. Хүүхэд гудамжинд гарч буй шалтгааны талаарх мэдээлэл байхгүй, цаашлаад найдвартай статистик тоо баримт байхгүй байгаад сэтгэл зовниж байна. Хүүхдүүдийг гудамжнаас холдуулахын тулд цагдаа нар дарамт үзүүлж байгаад харамсаж байна.

68. Хүүхдийг гудамжинд гарахад нөлөөлж буй үндсэн шалтгааныг ойлгох, эдгээр шалтгааныг арилгахын тулд нөхцөл байдлыг үнэлэх, гудамжны хүүхдийн хэрэгцээг шийдвэрлэхийн тулд эмзэг бүлгийн болон хамгаалал шаардлагатай хүүхдийн талаар яаралтай судалгаа хийх, хэрэгжүүлж байгаа хөтөлбөр төслүүдийг нэгтгэн дүгнэхийг Хороо Гишүүн улсад зөвлөж байна. Хороо Гишүүн улсад дараах зүйлийг зөвлөж байна.

- a) Цагдаагийн оролцооноос өөр хувилбараар нөхөн сэргээх, гэр бүлд нь эргэн нэгтгэх зэрэг хэлбэрээр гудамжны нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдийн эрхийг хамгаалах, тэдний дуу хоолойгоо сонсгох эрхийг баталгаажуулах зэрэг хүүхдийн эрхэд суурилсан цогц бодлого боловсруулах,
- b) Гудамжны нөхцөлд амьдарч буй хүүхдийн эрхийн талаар мэдлэг дээшлүүлэх,
- c) Нийгэм олон нийт, цагдаагийн ажилтан, нийгмийн ажилтан, хэвлэл мэдээллийн ажилтан, зэрэг гудамжны хүүхэдтэй ажилладаг бүх мэргэжилтнүүдийн чадварыг сайжруулах,
- d) Цагдаа нарыг хүүхдийн эрх, хамгааллын талаарх сургалтанд хамруулах.

**Бэлгийн мөлжлөг болон хүчирхийлэл**

69. Хүүхдийг эрсдэлд оруулж буй үндсэн шалтгаан хүчин зүйлийн талаар судалгаа хийж, баримт хөтлөх зэргээр хүүхдийг бэлгийн мөлжлөгөөс сэргийлэх үндэсний хэмжээний цогц бодлого боловсруулах талаар Засгийн газрын хэрэгжүүлсэн арга хэмжээг талархан хүлээн авч байна. Хэдий тийм ч, бэлгийн мөлжлөгийн хохирогч болсон хүүхдүүд, тэр дундаа охидуудтай гэмт хэрэгтэн мэт харьцаж, хангалттай хамгааллын үйлчилгээ үзүүлэхгүй байгаад Хороо сэтгэл зовниж байгаагаа тэмдэглэж байна. Цаашлаад, буруутан этгээдийг мөрдөн шалгах, яллах явдал дутагдалтай байгаад сэтгэл зовниж байна.

70. Хороо Гишүүн улсад дараах зүйлийг зөвлөж байна.

- a) Хүүхэд тэр дундаа охидыг бэлгийн мөлжлөгт өртөхөөс сэргийлэх талаар авч буй арга хэмжээг бэхжүүлэх,
- b) Хохирогч нарыг хамгаалж, тэднийг зохих нөхөн сэргээх, эргэн нийгэмшүүлэх үйлчилгээ хөтөлбөрт хамруулж, тэднийг гэмт хэрэгтэн мэт үзэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх,

- с) Бэлгийн хүчирхийллийн хохирогч нарын талаарх гэр бүлийн гишүүдийн ойлголтыг дээшлүүлж, тухайн хэргийн талаар ирсэн өргөдөл гомдлыг хүүхдэд мэдрэмжтэй, тэдний нууцыг хадгалсан байдлаар хэрхэн мөрдөн байцааж, хянах талаар хууль сахиулах ажилтан, нийгмийн ажилтан, шүүгч, прокурор нарыг чадвар бэхжүүлэх сургалтанд хамруулах,
- д) Байгууллагуудын дунд мэдээлэл солилцох, тоо баримт цуглуулах байдлыг сайжруулах,
- е) Нөхөн сэргээх тусламжийг нэн тэргүүнд тавьж, хохирогч хүүхдүүдэд боловсрол олгох, сургалтанд хамруулах, сэтгэл зүйн тусламж үзүүлэх, зөвлөгөө өгөх,
- ф) Бэлгийн хүчирхийлэл болон мөлжлөгтэй холбоотой бүртгэгдсэн гэмт хэргийг зохих ёсоор мөрдөн байцааж, буруутай этгээдийг шийтгэх.

71. Хүүхдийг хил дамнуулан худалдахтай тэмцэх талаар Гишүүн улсын авсан арга хэмжээг сайшаахын зэрэгцээ, бэлгийн мөлжлөг болон уул уурхайн салбарт ажиллуулах зэрэг бусад хэлбэрийн мөлжлөгт ашиглах зорилгоор хүүхдийг хохироох асуудал Гишүүн улсад байсаар байгаад Хороо сэтгэл зовниж байна. Хүнийг хил дамнуулан худалдах хэрэг, үүний хамрах хүрээний талаар найдвартай мэдээлэл дутмаг, хүн хил дамнуулан наймаалахаас сэргийлэх, хохирогч нарыг хамгаалж, тусламж үзүүлэх үйлчилгээг төсвөөс бараг санхүүжилт авалгүй Төрийн бус байгууллага, олон улсын байгууллагууд бие даан хийж байгаад Хороо сэтгэл зовж байна.

72. Хороо өмнөх дүгнэлт зөвлөмжид багтсан зөвлөмжийг (2005, 65 заалт) дахин өгч, дараах зүйлийг хэрэгжүүлэхийг Гишүүн улсаас шаардаж байна.

- а) Хүүхдийг хил дамнуулан болон улс хооронд худалдахаас хамгаалах бүх арга хэмжээг авах,
- б) Хүйсээр ялгаварлан гадуурхах, ядуурал зэрэг хүүхдийн худалдаа хил дамнуулан худалдахын үндсэн шалтаануудыг шийдвэрлэх хүч чармайлтыг бэхжүүлэх,
- с) Хүүхэд худалдах, хил дамнуулан худалдах хэргийн хохирогч болсон хүүхдүүдэд нийгмийн болон сэтгэл зүйн цогц тусламж үзүүлэх чиглэлээр бодлого хөтөлбөр боловсруулах, нөхөн сэргээх, эргэн нийгэмшүүлэх үйлчилгээнд хамруулахад хангалттай хэмжээний хөрөнгө мөнгө хуваарилах,
- д) Хүүхдийн худалдаа, хил дамнуулах худалдаалахтай холбоотой тоо баримт, нарийвчлалсан мэдээллийг цуглуулах тогтолцоог бүрдүүлэх,
- е) Холбогдох байгууллагуудтай хамтран урьдчилан сэргийлэх, ойлголт дээшлүүлэх арга хэмжээг авах.

### **Тусламжийн утас**

73. Одоогийн байдлаар хүүхдэд зориулсан утсаар тусламж үзүүлэх үйлчилгээг хэд хэдэн Төрийн бус байгууллагууд зохион байгуулж байгаад талархаж байна. Хэдий тийм ч, олон улсын стандартад нийцсэн, сайн ажиллагаатай, үнэ төлбөргүй, улс даяар үйл ажиллагаа явуулдаг тусламжийн утас байхгүй байгаад сэтгэл зовниж байна.

74. Хороо Гишүүн улсад тусламжийн утсыг сайжруулахыг зөвлөж байна, Үүнд:

- а) Гишүүн улсын бүх сум багуудад 24 цаг холбогдох боломжтой, 3 оронтой дугаар бүхий үнэ төлбөргүй утсыг хуваарилаж өгөх,

- b) Ойлголт дээшлүүлэх үйл ажиллагаа, сургалт, чадвар бэхжүүлэхэд хангалттай хэмжээний санхүүжилтийг хуваарилах,
- c) Хүүхдэд туслах зорилготой тусламжийн утасны үйлчилгээг тогтмол ажиллуулах нөөц бололцоогоор хангах.

**Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудлыг зохицуулах**

75. Урьдчилан хорих байранд байх хуулиар зөвшөөрөгдсөн хугацааг “Хүүхдийн хэрэг эрхлэх хороо” болон “Гэр хүрээ төв”-ийн дэмжлэгтэйгээр хязгаарласан, анх удаа гэмт хэрэг үйлдэж буй хүүхдийн ялын доод хэмжээг багасгасан зэрэг хүүхдийг эрхийг хамгаалах эрх зүйн хүрээг сайжруулах тал дээр Гишүүн улсын хийсэн хүчин чармайлтыг Хороо үнэлж байна. Гэвч, Хороо дараах зүйлд санаа зовнисоор байгаагаа илэрхийлье.

- a) Хүүхдийн урьдчилсан хорих байрны нөхцөл муу, ялангуяа урьдчилан хорих хугацаанд цагдаа нар хүч хэрэглэж, хэргийг хүчээр хүлээлгэдэг, цагдаагийн хорионд хүүхдүүдийг томчуудтай хамт байлгадаг талаар их хэмжээний гомдол ирж байгаа
- b) Ихэнх орон нутагт гэмт хэрэгт холбогдсон хүүхдүүдтэй ажилладаг мэргэжсэн шүүгч, шүүх дутмаг,
- c) Гэмт хэрэг үйлдсэн хүүхдэд эргэн нийгэмшүүлэх үйлчилгээ, тусламж үзүүлдэггүй, саатуулагдаж буй хүүхдэд боловсрол олгохгүй зөвхөн шийтгэхээ урьтал болгож залхаан цээрлүүлэх хандлагыг ашиглаж байгаа.

76. Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийг шүүх тогтолцоог Конвенц, тэр дундаа 37, 40, болон 39 дүгээр зүйл болон Нэгдсэн Үндэстний Байгууллагаас гаргасан “Насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг шүүн таслах ажиллагаа явуулахтай холбоотой наад захын дүрэм” (Бээжингийн дүрэм), “Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын зөвлөмж” (Риядын үндсэн зарчим), “Эрх чөлөө нь хязгаарлагдсан хүүхдийг хамгаалах тухай Нэгдсэн Үндэстний байгууллагын журам”, “Гэмт хэргийн улмаас хуулийн системд байгаа хүүхдэд үзүүлэх арга хэмжээний тухай” Венийн дүрэм зэрэг гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн талаарх Нэгдсэн Үндэстний Байгууллагын бусад стандарттай нийцүүлэхийг Гишүүн улсад Хороо дахин зөвлөж байна. Энэ талаар оролцогч улс:

- a) Урьдчилан хорих байранд байгаа хүүхдэд хүчээр хэрэг хүлээлгэхгүй байх, цагдаагийн хүчирхийлэлд өртүүлэхгүй байх, насанд хүрсэн хүнтэй хамт хорихгүй байх зэргээр тэнд хоригдож байгаа хүүхдийн эрхийг хамгаалах,
- b) Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудал шийддэг мэргэжсэн шүүхийг бүс нутаг бүрд байгуулж, тэнд тусгай бэлтгэгдсэн шүүгчийг томилох,
- c) Гэмт хэргийн улмаас хуулийн системд байгаа хүүхэдтэй ажилладаг бүх мэргэжилтнүүдийг хүүхдэд ээлтэй олон улсын стандартын талаар сургалтанд хамруулах,
- d) Эрх чөлөө нь хязгаарлагдсан хүүхдийн эрхийг хамгаалан хоригдож байгаа үеийн нөхцөл байдалд хяналт тавих, гэмт хэргийн улмаас хоригдож байгаа хүүхдүүдийг гэрийнхэнтэй тогтмол уулзаж байх боломжоор хангах,

- e) Аль болохоор тэнсэн харгалзах, зөвлөгөө өгөх, олон нийтэд тустай үйл ажиллагаанд албадан хамруулах, ялыг цуцлах зэрэг хорихоос бусад арга замыг хэрэглэх, гэмт хэрэг гарахад нөлөөлөсөн нийгмийн хүчин зүйлийг арилгах зэргээр насанд хүрээгүй хүүхдийн гэмт хэргийн асуудлыг шийдвэрлэхдээ Конвенцид тусгасан олон талт цогц арга зүйг ашиглах,
- f) Мөрдөн байцаалтын эхний үед хүүхдийг эрх зүйн болон бусад тусламжаар хангах,
- g) Бүх хүүхдийг нийгмийн суурь үйлчилгээгээр хангах,
- h) Хүүхдийн гомдлыг хүлээн авч шалгах хүртээмжтэй, бие даасан, хүүхдэд мэдрэмжтэй тогтолцоог бий болгож, хүүхдийн эрхийг зөрчсөн хууль сахиулах байгууллагын ажилтан болон хорихын хянагч нарын хэргийг мөрдөн байцааж, шүүхээр шийдвэрлэж, ял оноох,
- i) Хүүхдийн гэмт хэргийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг НҮБ–ын Байгууллага Хоорондын Цэцээс гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн чиглэлээр техникийн тусламж хүсэх, тэндээс явуулдаг цагдаагийн сургалтанд хамрагдах,
- j) Хүнийг тарчлаан зовоох, харгис, хүнлэг бусаар шийтгэхийн эсрэг 1984 оны конвенцийг соёрхон батлах талаар анхаарах, тарчлаан зовоох, харгис, хүнлэг бусаар шийтгэх явдалтай тэмцэх талаар зохих арга хэмжээ авах.

#### **Гэмт хэргийн хохирогч, гэрчийг хамгаалах**

77. Гишүүн улс зохих хууль тогтоомж, эрх зүйн хүрээгээр дамжуулан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн болон эдийн засгийн мөлжлөг, хүүхэд хулгайлах, хил дамнуулан худалдаалах хэргүүдийн хохирогч болон гэрч хүүхэд бүрийг Конвенцид заасны дагуу хамгааллаар хангах, ингэхдээ шүүх тогтолцоон дахь гэмт хэргийн хохирогч болон тэр хүүхдүүдтэй холбоотой асуудлаарх Нэгдсэн Үндэстний Байгууллагын зөвлөмжийг (2005 оны 7 дугаар сарын 22–ны өдөр Эдийн Засаг Нийгмийн Зөвлөлийн шийдвэр 2005/20–т хавсаргасан) бүрэн дагаж мөрдөхийг Хороо зөвлөж байна

#### **8. Олон улсын хүний эрхийн гэрээ хэлэлцээрийг соёрхон батлах**

78. Цагаач ажилчин бүрийн болон тэдний гэр бүлийн эрхийг хамгаалах олон улсын конвенц, Хүнийг ор сураггүй болгохоос хамгаалах олон улсын конвенц, Хүнийг тарчлаан зовоох, харгис, хүнлэг бусаар шийтгэхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протокол, Иргэний болон улс төрийн эрхийн гэрээний Нэмэлт Протокол, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн талаарх олон улсын гэрээний Нэмэлт Протокол зэрэг хараахан нэгдэн ороогүй НҮБ–ын хүний эрхийн үндсэн гэрээ хэлэлцээр болон тэдгээрийн Протоколыг Гишүүн орон соёрхон батлахыг Хороо зөвлөж байна.

#### **9. Зөвлөмжийг түгээх, хэрэгжүүлэх**

##### **Зөвлөмжийг хэрэгжүүлэх**

79. Энэхүү зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авах, тэр дундаа зөвлөмж нь Улсын Их Хурал, Засгийн газар, яам агентлагуудын дарга нар болон, түүнтэй адилтгах өндөр зэрэглэлийн албан тушаалтан, аймаг нийслэлийн



засаг дарга, иргэдийн хурлын дарга нарт хүрсэн, тэдний үйл ажиллагаанд тусгалаа олсон байх бүх арга хэмжээг авахыг Хороо зөвлөж байна.

### **Түгээх**

80. Конвенцийн хэрэгжилт, хяналтын талаар мэтгэлцээн өрнүүлж мэдлэг дээшлүүлэх үүднээс Монгол Улсын гурав дөрөвдүгээр тайлан, бичгээр өгсөн хариулт болон дүгнэлт зөвлөмжийг олон нийт, иргэний нийгэм, хүүхэд залуус, тэдний байгууллага, мэргэжлийн албад зэрэг нийгмийн бүхий л хүрээнд түгээх.

### **Дараагийн тайлан**

81. Гишүүн улс тав дахь тайлан илтгэлээ 2014 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Хороонд өргөн барихыг хүсэж байна. Дараагийн тайлан илтгэл нь 120 хуудсаас (CRC/C/118, 2002) илүүгүй байх ёстой бөгөөд Хүүхдийн эрхийн конвенцийн хоёр Нэмэлт Протоколын хэрэгжилтийн талаар мэдээллийг үүнд мөн багтаасан байна.

82. 2006 оны 6 дугаар сард хүний эрхийн гэрээ хэлэлцээрийн 5 дугаар Хороо Хоорондын хурлаар батлагдсан “Ердийн баримт бичиг болон гэрээ хэлэлцээр бүрт зориулсан баримт бичиг боловсруулах тухай зөвлөмж зэргийг багтаасан олон улсын хүний эрхийн гэрээ хэлэлцээрийн тайланг өгөх зөвлөмж”-д (HRI/MC/2006/3)заасан баримт бичиг бүрдүүлэх шаардлагын дагуу тайлангаа боловсруулж өргөн барихыг Хорооны зүгээс хүсч байна.

**6.6 ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ  
МОНГОЛ УЛСЫН ТАВДУГААР ТАЙЛАН**

**Товчилсон үг– үгийн тайлал**

ААН	Аж ахуйн нэгж
АНДЧ	Ази, Номхон далайн чуулган
АТГ	Авилгатай тэмцэх газар
АХБ	Азийн хөгжлийн банк
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БХИС	Батлан хамгаалахын их сургууль
ДБ	Дипломат байгууллагууд
ГХЯ	Гадаад харилцааны яам
ГИХАЭГ	Гадаадын иргэн харьяатын асуудал эрхлэх газар
ГЕГ	Гаалийн Ерөнхий газар
ДЗМОУБ	Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллага
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ИХШХЕГ	Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар
МУ	Монгол Улс
МУБИС	Монгол Улсын боловсролын их сургууль
МУИС	Монгол Улсын их сургууль
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МХЗ	Мянганы хөгжлийн зорилт
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрийн төв
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
МХХСТ	Монголын хэвлэлийн хүрээлэнгийн судалгааны төв
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
НҮБХС	Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн сан
НЛМ	Норвегийн тусламжийн байгууллага
НХҮЕГ	Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газар
НҮБХХ	НҮБ–ын Хөгжлийн хөтөлбөр
НҮЭМС	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа
НҮТС	Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа
ОУБТС	Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
СЗҮТ	Сэргээн засалтын үндэсний төв
СЗХГ	Стандартчилал, хэмжил зүйн газар
СЯ	Сангийн яам
ССАЖЯ	Соёл, спорт, аялал жуулчлалын яам
УУЯ	Уул уурхайн яам

УИХ	Улсын Их Хурал
ҮХААЯ	Үйлдвэр хөдөө аж ахуйн яам
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАХНХЯ	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам
ХТҮГ	Хүүхдийн төлөө үндэсний газар
ХТҮЗ	Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ХЭХтХ	Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль
ХЭХ	Хүүхдийн Эрхийн Хороо
ХЗЯ	Хууль зүйн яам
ХЯ	Хөдөлмөрийн яам
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ХИС	Хүүхдийг ивээх сан
ХХС	Хүүхэд хөгжил судалгаа
ХГБХХ/Г	Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс, газар
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ХЭЗ	Хүний эрхийн зөвлөл
ТББ	Төрийн бус байгууллага
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УДШ	Улсын Дээд Шүүх
УПЕГ	Улсын Прокурорын ерөнхий газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ШӨХТГ	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭЦГ	Эрүүгийн цагдаагийн газар
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв

**Хүүхдийн Эрхийн тухай НҮБ–ын Конвенцийн хэрэгжилтийн талаарх  
үндэсний тавдугаар тайлан бэлтгэх үйл явц, Тайлан бэлтгэх тогтолцоо**

Монгол Улсын Ерөнхий сайд, Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөлийн тэргүүн 2013 оны 11 дүгээр сарын 16 –ны өдөр 178 дугаар захирамж гаргаж, Хүүхдийн Эрхийн тухай НҮБ–ын Конвенцийн хэрэгжилтийн талаарх тавдугаар илтгэлийг боловсруулахыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яаманд даалгажээ. Иймд Үндэсний тайлан илтгэлийг зохих удирдамжийн дагуу боловсруулах салбар дундын Ажлын хэсгийг байгуулан түүнийг ХАХНХЯ–ны Төрийн нарийн бичгийн дарга Б. Отгонжаргал ахалж, ХТҮГ–ын ХТҮГ–ын Хүүхэд хамгаалал, үйлчилгээний газрын дарга Б.Жавзанхүү нарийн бичгийн даргаар ажиллав.

Тайлан боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд яам, агентлаг, иргэний нийгмийн байгууллагын өргөн төлөөлөл оролцсон болно. Засгийн Газрын шийдвэрийг хэрэгжүүлэх

ажлын хүрээнд бүх яам 2009–2014 онд Хүүхдийн Эрхийн тухай Конвенц болон Хорооны дүгнэлт зөвлөмжүүдийн хэрэгжилттэй холбоотой тайлан, статистик мэдээллийг Ажлын хэсэгт бэлтгэн ирүүлсэн юм.

Хүүхдийн Эрхийн тухай НҮБ–ын Конвенцийн хэрэгжилтийн тавдугаар тайлан илтгэл болон нийтлэг цөм, тайлангийн нэмэлт мэдээллийн эхний төслийг зөвлөх Б.Батхүү, С.Энхтуяа, П.Цэвээн, Б.Мөнхжаргал, Да.Энхтуяа нар боловсруулж, хянан толилуулах ажлыг Монгол Улсын гавъяат багш Ц.Түвшинтөгс гүйцэтгэв.

Тавдугаар илтгэлийн эхний төслийг ХТҮГ–ын цахим хуудсаар сурталчилж, төсөлд ирсэн 300 гаруй саналыг хүлээн авч, тайлангийн мэдээллийг чанаржууллаа.

Энэ удаа аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар, хэлтсүүд Хүүхдийн Эрхийн тухай Конвенцийн хэрэгжилтийн талаар орон нутгийн илтгэлийг анх удаа боловсруулав.

### Нэг. Ерөнхий мэдээлэл

#### Газар зүй, цаг уурын байдал

1. Монгол Улс нь Азийн эх газрын төв хэсэгт (өргөргийн 41°35'–52°09', уртрагийн 87 44'E –119°56'E) оршдог. Монгол Улсын баруунаас зүүн зах хүртэл 2392 км, хамгийн хойд цэгээс өмнө цэг хүртэл 1259 км. Нийт 1.565.000 км квадрат нутаг дэвсгэртэй. Хойд хэсгээрээ Оросын Холбооны улстай, баруун, өмнөд болон зүүн хэсгээрээ БНХАУ хиллэдэг. Газар нутгийн хэмжээгээрээ дэлхийд 19 дүгээр байранд ордог. Далайд гарцгүй хамгийн том газар нутагтай улсуудын нэг юм. Монгол Улсын газарзүй нь ерөнхийдөө өргөн уудам, далайн түвшнээс дээш дунджаар 914–1524 метр өргөгдсөн, баруу болон хойд хэсэгтээ уул нуруудтай. Зүүн өмнөд хэсэгт орших Алтайн уул нь далайн түвшнээс 4267 м өргөгдсөн.

2. Цаг агаарын нөхцөл нь маш хурдан өөрчлөгддөг. Монгол орны уур амьсгал хатуу ширүүн, газарзүйн байрлал, цагийн бүсээр тодорхойлогддог. Монгол Улс нь далайн түвшнээс дунджаар 1.5 км өргөгдсөн, далайгаас алслагдсан, өндөр уул нуруудаар хүрээлэгдсэн байдаг. Монгол Улс нь хуурай богино зун (6 дугаар сараас 8 дугаар сар), урт хүйтэн өвөл (11 дүгээр сарын сүүлчээс 4 дүгээр сар), хавар (4 дүгээр сарын эхээс 6 дугаар сар), намар (8 дугаар сарын сүүлчээс 10 дугаар сар) гэсэн 4 улиралтай. Жилийн дундаж хур тунадас зуны улиралд уулархаг нутгаар 388 мм, говийн бүсэд 50 мм–ээс бага ордог.

3. Агаарын хэм өвлийн улиралд –15°C –аас –30°C (–5°F–аас –22°F), зуны улиралд 10°C –аас 26.7°C (50°F–аас 80°F). Жилийн дундаж агаарын хэм Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар –4°C–аас бага, томоохон голын хөндийгөөр –6–аас –8 С, хээрийн бүсд 2°C–аас бага, говийн бүсэд 6°C–аас их байдаг. Цаг уурын хувьд эрс тэс уур амьсгалтай. Хур тунадас багатай, нутгийн умард хэсгээр жилд дунджаар 250–400 мм, өмнөд хэсэгт 100–150 мм тунадас ордог.

4. Газар нутаг нь хүрэн, хар хүрэн, цайвар хүрэн, хар шороон, нугын хүрэн, говийн бор, цөлийн бор саарал, нуга намгийн болон мараалаг, давсархаг зэрэг олон төрлийн хөрсний бүтэцтэй болно. Үүний дотор үржил шимт хүрэн хөрс газар нутгийн тавь орчим

хувийг эзлэх ба газар тариалан эрхэлж болох газар нь газар нутгийн 0.76%–г эзэлдэг. Усжуулалттай газар нутаг 840 км<sup>2</sup> байна. Монгол Улсад 67000 км урттай 3811 гол горхи, 500 м<sup>3</sup> эзэлхүүнтэй 3500 гаруй нуур, 7000 орчим булаг шанд, 540 м<sup>3</sup> талбай бүхий 190 гаруй мөсөн гол, 250 гаруй рашаантай бөгөөд газрын доорхи усны 139 орд байна. Монгол Улсын гол мөрнийг Хойд мөсөн далайн, Номхон далайн болон Төв Азийн гадагшаа урсгалгүй сав газрын гэж гурав хуваана. Орхон бол Монголын хамгийн том гол юм (Урт нь 1124 км, усаа цуглуулах талбай 133000 км<sup>2</sup>). Хамгийн том нуур нь Увс (3350 км<sup>2</sup>), хамгийн гүнзгий нуур нь Хөвсгөл (262.4 м) юм.

5. Нийт нутгийн 41.3 хувийг говь цөл, хээрийн бүс, 10 хүрэхгүй хувийг ой мод эзэлдэг. Монгол Улсад нэг ба олон наст, модлог, бутлаг, хагас бутлаг зэрэг 4000–аад зүйлийн ургамал, ногоо ургадаг бөгөөд 7 баг, 24 овог, 70 гаруй төрөлд хамаарагдах 140 гаруй зүйлийн хөхтөн, 390–ээд зүйлийн жигүүртэн оршино. Эрдсийн түүхий эд, ашигт малтмал, түүний дотор алт, зэс, уран, чулуун нүүрсний баялаг нөөцтэй бөгөөд эдгээр баялгийн ордоороо олон улсын ач холбогдолтой.

### **Түүх, соёл**

6. Өнөөгийн Монгол Улсын нутагт одоогоос ойролцоогоор нэг сая жилийн өмнөөс хүн амьдарч байсан гэсэн судалгаа байдаг. МЭӨ IV зуунд үүссэн Хүннү гүрэн нь Монголын газар нутаг дахь нүүдэлчдийн анхны хүчирхэг улс гүрэн байсан. Хүннү гүрэн нь хамгийн хүчирхэг үедээ баруун зүгт Түрэгстан, зүүн зүгт Хянганы нуруу, хойд зүгт Байгаль нуур, өмнө зүгт Цагаан хэрэмд тулсан өргөн уудам нутгийг эзэлж байжээ. Анхны төрт улс Хүннү гүрэн байгуулагдсаны 2200 жилийн ой 2011 онд, Чингис хааны үүсгэн байгуулсан Их Монгол Улсын 800 жилийн ой 2006 онд тохиосон. XVII зууны эцсээр Манж чин гүрний эрхшээлд орсон ба 200–аад жилийн дараа үндэсний эрх чөлөөний тэмцлээр 1911 онд тусгаар улсаа зарласан ба улмаар 1924 оны 11 дүгээр сарын 26–ны өдөр Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг тунхагласан юм. 1940–өөд оноос тэр үеийн ЗХУ–ын дагуул улс болж, социалист хамтын нөхөрлөлийн бүрэлдэхүүнд 40 гаруй жилийг туулсан. Монгол Улс 1961 онд НҮБ–д гишүүнээр элссэн юм. Анхны ардчилсан сонгууль 1990 оны долдугаар сард явагдаж, ардчилсан төр тогтсон билээ. Шинэ Үндсэн Хуулиа 1992 онд баталж, 1993 оны зургаадугаар сарын 6–ны өдөр Ерөнхийлөгчийн анхны шууд сонгууль явагдсан.

7. Монголчууд бол эртний соёлт ард түмний нэг. Монгол хэл нь алтай язгуурын, баялаг үгийн сантай, боловсорсон хэл бөгөөд өдгөө бидний монголчууд 1000 жилийн түүхтэй монгол бичгээ кирилл үсэгтэй зэрэгцүүлэн хэрэглэж байна. Монгол бөх, морины уралдаан, нум сумын харваа, уртын дуу, хөөмий, бие биелгээ зэрэг нь Монголчуудын дэлхийн оюуны соёлын санд оруулсан үнэт хувь нэмэр юм.

### **Хүн амын байдал**

8. Монгол Улс 2. 9 сая хүн амтай, түүний 10 шахам хувийг ахмад настан, 27.7 хувийг 0–14 насны хүүхэд, 37.5 хувийг 15–34 насны өсвөр үе, залуучууд эзэлж байна. Сүүлийн 44 жилд хүн амын тоо 2.6 дахин нэмэгдсэн ба өрхийн тоо 3 дахин өсчээ. Нийт хүн амын 51.3 хувь нь эмэгтэйчүүд, 48.7 хувь нь эрэгтэйчүүд, хүн амын дундаж өсөлт 1.4 хувь байна. Дундаж наслалт 2013 онд 69.1 жил, эрэгтэйчүүдийнх 65.4, эмэгтэйчүүдийнх

75.0 байна. Хүн амын 67.2 хувь нь хот суурин газарт амьдарч, сүүлийн арван жилд хөдөөгөөс хот суурин газарт шилжих хөдөлгөөн эрчимжиж, хотын хүн амын тоо эрс нэмэгдэж байна. Хүний хөгжлийн индекс 0.787 байна.

9. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр 713.8 мянган өрх тоологдсон нь 2000 оныхтой харьцуулахад 31.9 хувиар нэмэгдсэний дотор хотын өрх 61.9 хувиар өсч, хөдөөгийн өрх 4.3 хувиар буурчээ. Монгол Улсын хүн амын 82.4 хувийг халх, 3.9 хувийг казах, үлдсэн хувийг буриад, дөрвөд, дархад, тува, уйгур зэрэг үндэстэн ястнууд эзэлж байна.

10. Монгол Улсын 15–аас дээш насны нийт хүн амын 61.4 хувь нь шашин шүтлэгтэй, үлдсэн 38.6 хувь шашингүйчүүд байна. Шашин шүтлэгтэй хүн амын 86.2 хувь нь буддын шашинтан, үлдсэн хувь нь ислам, христ, бөө мөргөлийн шүтлэгтэн байна. Буриадуудын 21.0 хувь, Дархаддуудын 41.5 хувь, Тувачуудын 46.2 хувь, Хамниганчуудын 30.6 хувь, Цаатангуудын 85.0 хувь бөө мөргөлийн шүтлэгтэй байна.

11. Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) өсөлт 2009 онд –1.3% байсан бол 2010 оноос эерэг өсөлт бий болж эхэлсэн бөгөөд 2013 он гэхэд 11.7% болсон. Нэг хүнд оногдох ДНБ 2009 онд тухайн оны үнээр 2449 төгрөг байсан бол 2013 онд 6052.7 төгрөг болсон байна.

### **Эдийн засгийн байдал**

12. Монгол Улс чөлөөт зах зээлийн эдийн засагт амжилттай шилжиж, сүүлийн 10 жилийн дотор уул уурхайн салбарыг эрчимтэй хөгжүүлснээр төсвийн орлого огцом нэмэгдэж, 2011 онд эдийн засгийн өсөлт 17.3 хувьд хүрч урьд өмнө байгаагүй дээд амжилтаа тогтоолоо. Гэсэн хэдий ч инфляцийн түвшин хоёр оронтой тооноос буурахгүй байна. 2014 оны эхний хагас жилд ДНБ өсөлт 5.3 хувь, ажилгүйдлийн түвшин 8.4 хувь, инфляцийн түвшин 14.9 хувь байна.

13. 2011–2012 оны Дэлхийн өрсөлдөх чадварын тайланд “Монгол Улс нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн түвшний хувьд үйлдвэрлэлийн хүчин зүйлсэд тулгуурласан хөгжлийн нэгдүгээр үе шатнаас бүтээмжид суурилсан хоёрдугаар шатанд шилжиж байгаа улс” гэж тэмдэглэсэн ба Монгол Улс дунджаас доогуур орлоготой орнуудын ангилалд багтан орсон.

14. Ядуурлын түвшин 2010 онд 38.7 хувь байсан бол 2012 онд 27.4 хувьд хүрч буурсан. Ядуурлын түвшин 2012 оны байдлаар Улаанбаатар хотод 19.8 хувь, орон нутагт 39.8 хувь байгаагаас аймгийн төвд 30.4 хувь, сумын төвд 27.5 хувь байна. Ядуурлын жини коэффициентийн улсын дундаж үзүүлэлт 0.34 хувь байна.

15. Өрх толгойлсон ганц бие хүний тоо 107.2 мянга болж, 2004 онтой харьцуулахад 22.9 мянгаар нэмэгдсэн. Үүнээс эмэгтэйчүүд толгойлсон өрх 76.2 хувийг эзэлж байна. Улсын хэмжээнд 18 хүртэл насны хүүхэдтэй өрх толгойлсон эх 39.9 мянга байгаа ба 8 ба түүнээс дээш ам бүлтэй өрхийн 60 гаруй хувь нь ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй байна.

**Хоёр. Үндсэн хууль, улс төр, эрх зүйн бүтэц**

16. 1992 онд батлагдсан Үндсэн хуулиар Монгол Улс нь парламентын бүгд найрамдах улс мөн. Хууль тогтоох дээд байгууллага нь Улсын Их Хурал, гүйцэтгэх дээд байгууллага нь Засгийн Газар, шүүхийн дээд байгууллага нь Дээд Шүүх болно.

17. Хууль тогтоох дээд байгууллага болох Улсын Их Хурал нь бүх нийтийн сонгуулиар байгуулагддаг, нэг танхимтай, 76 гишүүнээс бүрддэг, хууль тогтоох онцгой эрх мэдлийн байгууллага юм. Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно. Улсын Их Хурлын сонгуулийн журам, үйл ажиллагааг хуулиар тогтооно.

18. Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн. Ерөнхийлөгчөөр дөчин таван нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэн дөрвөн жилийн хугацаагаар сонгогдох бөгөөд хууль санаачлах, хуульд хориг тавих эрхтэй, шүүгчдийг томилох, чөлөөлөх, Ерөнхий сайдыг томилох саналыг УИХ-д оруулах эрх, үүрэгтэй. Ерөнхийлөгчийг Улсын Их Хуралд суудалтай улс төрийн нам, эвслээс нэр дэвшүүлж, бүх ард түмний сонгуулиар шууд сонгодог. Ерөнхийлөгч нь Монголын ард түмний эв нэгдлийн бэлгэдэл учраас Ерөнхийлөгчөөр сонгогдсон хүн аливаа улс төрийн намын харьяаллаас татгалздаг.

19. Засгийн Газрын бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна. Засгийн Газрын бүрэн эрх Улсын Их Хурлаас Ерөнхий сайдыг томилсноор эхэлж, дараагийн шинэ Ерөнхий сайдыг томилсноор дуусгавар болно. Ерөнхий сайд Засгийн Газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна. Засгийн Газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана.

20. Засгийн Газар нь Ерөнхий сайд, гишүүд (сайд нар)-ээс бүрддэг ба ерөнхий чиг үүргийн болон чиглэлийн яамд тухайн салбарын бодлого боловсруулах, ерөнхий ба салбарын чиг үүргийг хариуцна. Засгийн Газрын гишүүн буюу сайдын эрхлэх ажлын хүрээнд тохируулагч ба хэрэгжүүлэгч агентлагууд байна. Монгол Улсын Засгийн Газар 2008 –2012 онд 11 яам, тохируулах чиг үүргийн 9 агентлаг, хэрэгжүүлэх чиг үүргийн 32 агентлагтай байсан бол 2012 –2014 оны хооронд 16 яам, тохируулах 11, хэрэгжүүлэх 17 агентлагтай болгон өөрчлөн зохион байгуулжээ.

21. Шүүхийн дээд байгууллага нь Дээд Шүүх болно. Шүүх эрх мэдлийн хүрээнд шүүхийн бүх шатны байгууллага, прокурорын байгууллага, тэрчлэн Үндсэн хуулийн цэц багтан ажилладаг. Шүүхийн тухай хуулийн дагуу үндсэн тогтолцоо нь Улсын Дээд Шүүх /хяналтын шатны шүүх/, аймаг, нийслэлийн шүүх /давж заалдах шатны шүүх/, сум буюу сум дундын, дүүргийн шүүх /анхан шатны шүүх/-ээс бүрддэг. Улсын Дээд Шүүхээс бусад шүүхийг нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, шийдвэрлэх хэрэг, маргааны тоог харгалзан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэд хэдэн нэгжийг харьяалуулан эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулна. Шүүх

байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгаар 2013 оны нэгдүгээр сараас эхлэн аймаг, нийслэлийн давж заалдах шатны шүүхийг иргэний, эрүүгийн болон захиргааны шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж, тэдгээрийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг дор дурдсанаар тогтоожээ.

22. Нутаг дэвсгэр нь засаг захиргааны хувьд аймаг, нийслэл, сум дүүрэг, баг хороонд хуваагдах ба эдгээр нэгжийн удирдлага нь өөрөө удирдах ёсны нийтийн ба Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төрийн удирдлага хэрэгжүүлэгч нь бүх шатны Засаг дарга нар болно. Засаг захиргааны хувьд 21 аймаг, 362 сум, 9 дүүрэгтэй.

23. Дэлхийн нийт 173 улс оронтой дипломат харилцаатай, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулдаг. Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлдэг. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ. Үндсэн хуульд харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй болохыг Үндсэн хуулиар баталгаажуулсан болно.

24. Төрийн бус байгууллага байгуулах, бүртгүүлэх харилцааг “Төрийн бус байгууллагын тухай”, “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай” болон “Иргэний хууль”-иар зохицуулдаг. Холбоо, сан байгуулах харилцааг “Иргэний хууль”-иар зохицуулж байна. Төрийн бус байгууллагыг 2003 оноос эхлэн “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай” хуулийн дагуу улсын бүртгэлийн байгууллага бүртгэж байна. Монгол Улсад 2013 оны байдлаар төрийн бус байгууллага 16288, сан 659, үйлдвэрчний эвлэлийн байгууллага 2167 үйл ажиллагаа явуулж байна.

25. Монгол Улсад 2009 онд 20373 гэмт хэрэг бүртгэгдэж, 7513 хүн шүүхээр шийтгүүлж ял авсан байдаг бол 2013 онд 25362 гэмт хэрэг бүртгэгдэж, 8067 хүн шүүхээр ял шийтгүүлсэн байна. 2013 онд шүүхээр ял шийтгүүлэгчдийн нийт хүний 696 нь эмэгтэй, 504 нь 18 хүртэл насны хүүхэд байв. Мөн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэргийн 46.8% нь өмчлөх эрхийн гэмт хэрэг, 34% нь хүний амь, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг байв. Улсын Дээд Шүүхийн 2013 оны эхний хагас жилийн дүн статистикаас харахад 2013 оны эхний жилд 4087 хүн ял шийтгүүлснээс 3086 хорих ялаар шийтгүүлсэн бөгөөд үүний 1261 нь хорих ялыг биеэр эдлүүлэх, 1563 нь тэнссэн, 243 нь хорих ялыг хойшлуулсан, 188 насанд хүрсэн ба насанд хүрээгүй, 9 хүнд өршөөл үзүүлсэн байна. Мөн хорихоос өөр ялаар буюу торгох, албадан ажил хийлгэх, баривчлах зэрэг ялын хэлбэрээр 933 хүн шийтгүүлсэн байна.

26. Шашин сүм хийдийн харилцааг хуулиар зохицуулдаг ба төр шашин харилцан тус тусын хэрэгт үл оролцох зарчим, иргэдийн шүтэх, эс шүтэх эрх чөлөөг баталгаажуулж, шашны урсгалууд орж ирэх нөхцөлийг хангасан болно. Одоо тус улсад Будда, Христ, Ислам, Бахай, Бөө мөргөл, Мүүн шашны байгууллагууд бүртгүүлэн үйл ажиллагаа явуулж байгаагаас 50 гаруй хувь нь Буддын, 40 орчим хувь нь Христийнх байна.

27. Монгол Улсад 2012 оны байдлаар Дээд Шүүхэд бүртгэлтэй 21 нам байгаагаас 2012 оны УИХ-ын сонгуулийн дүнгээр Ардчилсан Нам 31, Монгол Ардын Нам 25, МАХН-МҮАН –ний Шударга ёс эвсэл 11, Иргэний Зориг-Ногоон Нам 2 суудалтай байна.



**Гурав. Хүний эрхийг хамгаалах ба хөхиүлэн дэмжих**

**Олон улсын хүний эрхийн хэм хэмжээг хүлээн зөвшөөрөх талаар:**

28. Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхтэй холбоотой Олон улсын үндсэн баримт бичгийн мэдээллийг энэ хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 1. Хүний эрхийн чиглэлээр Монгол Улсын нэгдэж орсон НҮБ-ын Конвенц*

Конвенцийн нэр	Нэгдэн орсон/ Баталсан
Боловсролын талаар алагчлахтай тэмцэх тухай Конвенц (1960)	1964
Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай Конвенц (1952)	1965
Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай Конвенц (1948)	1966
Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай Конвенц (1966)	1969
Дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг үл хэрэглэх тухай Конвенц (1968)	1969
Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пакт (1966)	1974
Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай Олон улсын пакт (1966)	1974
Апартеидын гэмт хэргийг таслан зогсоох, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай Конвенц (1973)	1975
Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц (1979)	1981
Спортод апартеид бодлого явуулахын эсрэг олон улсын Конвенц (1985)	1987
Хүүхдийн Эрхийн тухай Конвенц (1989)	1990
Сайн дурын үндсэн дээр гэрлэх, гэрлэх насны доод хязгаар болон гэрлэлтийг бүртгэх тухай конвенц (1962)	1991
Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын Нэмэлт I Протокол (1966)	1991
Хүүхдийн Эрхийн тухай Конвенцийн 43 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт оруулах нэмэлт өөрчлөлт (1995)	1997
Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт оруулсан нэмэлт өөрчлөлт (1995)	1997

**ЗУРГАДУГААР БҮЛЭГ**

Конвенцийн нэр	Нэгдэн орсон/ Баталсан
Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенц (1984)	2001
Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн Нэмэлт Протокол (1999)	2001
Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол (2000)	2001
Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчилахын эсрэг Хүүхдийн Эрхийн тухай Конвенци Нэмэлт Протокол (2000)	2002
Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенц (2006)	2008
Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенци (2006)	2008
Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Олон улсын пактын Нэмэлт Протокол (2008)	2010
Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пактын Цаазаар авах ялыг халахад чиглэсэн Нэмэлт II Протокол (1989)	2012

**ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ**

*Хүснэгт 2. Олон улсын хөдөлмөрийн  
байгууллагын гэрээ, конвенц*

<b>Конвенцийн нэр</b>	<b>Нэгдэн орсон он</b>
<b>Аж үйлдвэрийн салбарт ажилд авах насны доод хязгаарын тухай (59)</b>	1969
Зохион байгуулах ба хамтын хэлэлцээ хийх эрхийн тухай (98)	1969
Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө ба зохион байгуулах эрхийг хамгаалах тухай (87)	1969
Адил цалин хөлс олгох тухай (100)	1969
Алагчлахгүй байх тухай (Хөдөлмөр эрхлэлт, ажил мэргэжилд) (111)	1969
Үйлдвэрийн газарт ажилчдын төлөөлөгчдийн эрхийг хамгаалах болон тэдэнд олгогдох бололцооны тухай (135)	1974
Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний хэрэгжилтийг дэмжих гурван талт зөвлөлдөөний тухай (144)	1998
Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай (122)	2005
Албадлагын хөдөлмөрийн тухай (29)	2005
Албадлагын хөдөлмөрийг устгах тухай (105)	2005
Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах тухай (182)	2000
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай (155)	1998
ХБИ-ийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай (159)	2002
Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай (138)	1981
Газар доор буюу уурхайд ажиллагсадын ажилд авах насны доод хязгаарын тухай (123)	1981
Эхчүүдийн хамгааллын тухай (103)	1969

*Хүснэгт 3. Хүний эрхийн олон улсын бусад гэрээ*

<b>Гэрээ, Конвенцийн нэр</b>	<b>Элссэн/ соёрхон баталсан</b>
Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай Конвенц (1993)	1998
Олон Улсын Эрүүгийн Шүүхийн тухай Ромын Дүрэм	2002
<b>Тамхины хяналтын суурь Конвенц (2003)</b>	2004
<b>Спортод сэргээшийн эсрэг Копенгагены тунхаглал (2005)</b>	2007

29. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг Конвенцийн Нэмэлт Протокол, Хүнийг хүчээр алга болгохоос хамгаалах тухай Конвенц, Хүүхдийн Эрхийн тухай Конвенцийн Мэдээлэл хүргүүлэх журмын тухай гуравдугаар нэмэлт протоколд Монгол Улс гарын үсэг зурж, УИХ-д өргөн барьсан.

30. Монгол Улсын Засгийн Газар нь нэгдэн орсон буюу хүлээн зөвшөөрсөн олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг өөрийн орны нутаг дэвсгэрт хангах, хэрэгжилтийн байдал, тулгарч байгаа хүндрэл, шалтгааны талаарх тайланг тухайн олон улсын гэрээ, хэлэлцээрийн баримт бичигт заасан хугацаанд холбогдох байгууллагуудад танилцуулан ажиллаж байна. *Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт-ын хэрэгжилтийн талаарх ээлжит 5 дахь илтгэлийг 2009 оны есдүгээр сард* Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргын газарт хүргүүлж, 2011 онд *НҮБ-ын Хүний эрхийн хорооны 101 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлсэн*. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт-ын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын үндэсний дөрөвдүгээр илтгэлийг 2011 онд НҮБ-д хүргүүлсэн. Уг тайлан илтгэлийг төрийн болон ТББ-уудын дунд 2 удаа зохион байгуулж, холбогдох яам, агентлаг, хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 30 гаруй ТББ болон НҮБ-ын төрөлжсөн байгууллагын төлөөлөгч, мэргэжлийн хүмүүсийг оролцуулж боловсруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийн хэрэгжилтийн талаарх үндэсний анхдугаар илтгэлийг 2012 онд НҮБ-ын ЕНБДГ-т хүргүүлсэн. Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын Конвенцийн хэрэгжилтийг хангах чиглэлээр авсан арга хэмжээ, ололт дэвшлийн талаар тайланг НҮБ-ын ЕНБДГ-т 2013 онд хүргүүлсэн.

Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн хэрэгжилтийн талаарх үндэсний 8–9 дүгээр илтгэлийг 2014 оны есдүгээр сард НҮБ-д хүргүүлээд байна.

31. Монгол Улсын нэгдэн орсон буюу хүлээн зөвшөөрсөн Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын дараах олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийн тайланг хүргүүлсэн байна. Үүнд: Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, зохион байгуулах эрхийг хамгаалах тухай Конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын ээлжит тайланг 2012 онд, “Зохион байгуулагдах эрх ба хамтын хэлэлцээ хийх тухай” конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн Газрын ээлжит тайланг 2010, 2012 онд, Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний хэрэгжилтийг дэмжих гурван талт зөвлөлдөөний тухай Конвенцийн хэрэгжилтийн тухай Монгол Улсын Засгийн Газрын тайланг 2010 онд, Ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтэд алагчлахгүй байх тухай 111 дүгээр Конвенцийн хэрэгжилтийн тухай Монгол Улсын Засгийн Газрын илтгэл 2011 онд, Албадан Хөдөлмөрийг устгах тухай Конвенцийн хэрэгжилтийн Монгол Улсын Засгийн Газрын тайланг 2013 онд хүргүүлэв.

### **Үндэсний хууль тогтоомжид хүний эрхийг хамгаалах талаар тусгагдсан байдал**

32. Монгол Улсын Үндсэн хуульд иргэдийн эдлэх эрх, эрх чөлөөг бие даан бүлэг болгон тодорхойлсны дотор амьд явах эрх (16); ажил мэргэжлээ чөлөөтэй сонгож, хөдөлмөрийн аятай нөхцөл, цалин хөлсөөр хангагдах, амрах эрх (16–4); өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, хүүхэд төрүүлэх, асрах, тодорхой нөхцөлд эд, мөнгөн тусламж авах эрх (16–5); эрүүл мэндээ хамгаалах, эмнэлгийн тусламж авах эрх (16–6);

сурч боловсрох, ерөнхий боловсролд төлбөргүй суралцах эрх (16–7)–ийг тодорхой заасан байна.

33. Үндсэн хуульд заасан дээрх эрхийг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн нарийвчилсан зохицуулалтыг тус тусын салбарын хуулиудад тусгасан. Монгол Улсын Үндсэн Хуульд заасны дагуу Монгол Улсын соёрхон баталсан буюу нэгдэн орсон олон улсын гэрээ нь хүчин төгөлдөр болсон цагаасаа үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ. Засгийн газрын 2012–2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт “ардчилсан нийгмийн үнэт зүйл, зарчим, улс орны хөгжлийн шаардлагад нийцсэн, урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцох чадавхтай эрүүгийн хууль тогтоомжийн тогтолцоог бүрдүүлж, ялын бодлогыг оновчтой үр нөлөөтэй, олон сонголттой болгох” зорилтыг дэвшүүлсэн билээ. Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан үнэт зүйлсийг материаллаг хуулиар хамгаалахдаа гэмт хэрэг, зөрчлийн шинжийг ойлгомжтой, хэрэглэхэд хялбар байдлаар, өнөөгийн нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өөрчилж, томъёолохоос гадна шинээр хамгаалах шаардлагатай харилцаа, хүний эрх, эрх чөлөө, хүний халдашгүй байдлыг хамгаалах хууль эрх зүйн баталгаатай орчныг бүрдүүлэхэд Гэмт хэргийн тухай хуулийн шинэтгэл чиглэж байна. Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд 2012 онд шүүхийн үйл ажиллагаатай холбоотой 6 багц хууль батлагдан хэрэгжиж байгаа бөгөөд Монгол Улсын Шүүх анх удаа тойргийн тогтолцоонд шилжин ажиллаж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Шүүхийн тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг 2012 оны 03 дугаар сарын 07–ны өдөр, Шүүхийн захиргааны тухай хууль, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийг 2012 оны 05 дугаар сарын 12–ны өдөр УИХ–аар батлуулсан нь шүүхийн шинэтгэлийн хүрээнд хийсэн томоохон ажил боллоо.

34. Хүний эрхийн хамгаалалтын чухал хэрэглүүр нь хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага юм. Энд дурдсан салбарын бүх хуульд зөрчлийн улмаас хохирогсдод олгох нөхөн олговор, төлбөр хийх болон зөрчигч этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхой тусгасан.

## **1. Үндэсний түвшинд хүний эрхийг хөхиүлэн дэмжих талаар**

35. Монгол Улсад хүний эрхийг хамгаалах, хангах чиглэлээр Хүний эрхийн Үндэсний зөвлөл, Хүний эрхийн Үндэсний комисс, Жендэрийн тэгш байдлын Үндэсний зөвлөл, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг– Хүүхдийн төлөө Үндэсний газар, Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөл, Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороо, Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөл, Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөл зэрэг байгууллага ажиллаж байна. Боловсрол, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, дэд бүтцийн зэрэг яамдад хүний эрхийг хэрэгжүүлэх ерөнхий ба мэргэжлийн чиг үүрэг бүхий агентлагууд ажиллаж байна.

36. Улсын Их Хурал нь соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээ болон шаардлагатай гэж үзсэн Монгол Улсын олон улсын аливаа гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж байна. Монгол Улсын Засгийн Газар өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар

байгуулсан олон улсын гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж биелэлтийг зохион байгуулж ажилладаг. Зохицуулж буй асуудлыг Засгийн Газрын эрхэлсэн гишүүн болон агентлагийн дарга олон улсын гэрээний биелэлтийг гаргаж, жил бүрийн 6 ба 12 дугаар сарын 20-ны дотор гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлж байх бөгөөд гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олон улсын гэрээний биелэлтийн явцыг нэгтгэн дүгнэж шаардлагатай тохиолдолд саналаа Засгийн Газарт оруулж хэлэлцүүлдэг.

37. Амьд явах эрх. Монгол Улсад Үндсэн хуульд Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно гэж заасан. Одоо хүчин төгөлдөр Эрүүгийн хуулиар цаазаар авах ялыг 81.2 /Төр, нийгмийн зүтгэлтний амь, биед халдах/, 84.1/ Хорлон сүйтгэх/, 91.2 /Хүнийг санаатай алах/, 126.3 /Хүчиндэх/, 177.2 /Зандалчлах/, 178.2 /Терроизм/, 302.1 /Төрлөөр устгах/ гэсэн онц хүнд гэмт хэрэгт оногдуулж байна.

38. Монгол Улс 2009 оноос хойш цаазаар авах ял гүйцэтгээгүй. Монгол Улсын Ерөнхийлөгч Ц. Элбэгдорж 2010 оны нэгдүгээр сарын 14 –ний өдөр цаазаар авах ялын гүйцэтгэлд мораториум зарласан бөгөөд манай Монгол Улс 2012 онд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын Цаазаар авах ялыг халах тухай Нэмэлт Протколд нэгдэн орсон. УИХ-ын энэ намрын чуулганаар өргөн бариад буй шинээр боловсруулсан Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд цаазаар авах ялыг хассан байна.

39. Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх. Хүн амын эрүүл, аюулгүй амьдрах орчинг бүрдүүлэх үүднээс агаар, ус, хөрсний бохирдол, хүнс, авто зам, барилгын аюулгүй байдлыг хангахтай холбоотой стандартуудыг баталж, агаарын бохирдлын хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөлд үндэслэн хот суурин газрын агаарын чанарыг үнэлж, олон нийтэд мэдээлэхэд ашигладаг агаарын чанарын индексийг тооцох аргачлал, журмыг батлан мөрдүүлж байна.

40. Улаанбаатар хот, томоохон аймгийн төв, суурин газруудын агаарын бохирдолыг бууруулах зорилгоор Ерөнхийлөгчийн дэргэд Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороог байгуулж ажилласан бөгөөд 2013 онд Агаарын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотой Үндэсний хороог Ерөнхий сайд ахлах болжээ. Агаарын бохирдлыг бууруулахын тулд айл өрхийг боловсруулсан түлш, сайжруулсан шаталттай зуухаар хангах, монгол гэрийн дулааны алдагдлыг бууруулах, цахилгаан халаагуур ашиглах, жижиг, дунд чадлын ус халаагуурын зуухнуудыг нэгдсэн сүлжээнд холбох зэрэг олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

41. Уул уурхайн үйлдвэрлэл, ялангуяа алт олборлолтын нөлөөгөөр 8 аймгийн 28 гол горхи 2011 он хүртэл хугацаанд бохирдсон байв. Үүнтэй холбоотойгоор УИХ Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг баталж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

42. Хүн амыг тамхи, дам тамхидалтын хор нөлөөллөөс хамгаалах, эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс Тамхины хяналтын тухай хуулийг 2013 онд

баталсан. Энэ хууль батлагдсанаар нийтийн тээврийн хэрэгсэл, агаарын хөлөг, галт тэрэгний болон усан онгоцны зорчигчдын өрөө /купе/, хонгил, шатахуун түгээгүүрийн газар, шатах, тослох, тэсэрч дэлбэрэх бодис, материалын үйлдвэр, түүний нөөцийн агуулах, мөн зорчигч тээврийн буудал, зочид буудлын нийтийн үйлчилгээний танхим, нийтийн хоол, худалдаа, үзвэр, үйлчилгээ, баар, цэнгээний газар, аливаа байгууллага, аж ахуй нэгжийн албан байранд тусгайлан зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт утаат тамхи татахыг хориглосон болно.

43. Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрх. Үндсэн хуульд "...хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн, хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө" гэж заасан.

44. Монгол Улсад 2003 оноос хойш компани, нөхөрлөл, хоршоо, банкны тухай хууль тогтоомжоос гадна өмчлөх болон аж ахуй эрхлэхтэй холбоотой бусад харилцааг зохицуулсан эрх зүйн орчин бүрдсэн. Төрийн өмчид байсан үйлдвэр, аж ахуйн газруудыг эрхийн тасалбараар хувьчлах, мал болон орон сууцыг төрөөс үнэгүй хувьчлах ажлыг амжилттай хийсэн. Нийслэлд 2003 –2010 онд 13 удаа гэр бүлийн зориулалтаар иргэдэд газар өмчлүүлэх газрын байршил, зориулалт, хэмжээг тодотгож хэрэгжүүлсэн бөгөөд одоогийн байдлаар 4623,9 га газрыг 84867 хүнд өмчлүүлсэн нь Нийслэлийн газар өмчлөлийн 10,15 хувь болж байна.

45. Нийслэлийн авто замын хөдөлгөөний түгжрэл, саатлыг бууруулах зорилгоор Нийслэлийн Засаг дарга 2013 онд Замын хөдөлгөөний удирдлагын төвийн дүрэм, бүтэц орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай захирамжийг гаргасан.

46. Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрх. Монгол Улсад хүн бүр чөлөөтэйгөөр ажил, хөдөлмөрөө сонгох, мэргэшэх, шударга, ая таатай хөдөлмөрийн нөхцөлөөр хангуулах эрх зүйн орчин бүрдсэн. Сүүлийн жилүүдэд уул уурхай, санхүү, худалдааны салбарын өсөлт нь эдийн засгийн орчинд таатай нөлөө үзүүлээ. Монгол Улсын эдийн засгийн өсөлт нэмэгдэх хэрээр нэрлэсэн дундаж цалин өсч байгаа ч инфляцийн түвшингээс хамааран бодит цалингийн өсөлт харилцан адилгүй байна.

47. Өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрх Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хуульд 2011 онд өөрчлөлт оруулснаар дан ганц гэрээгээр хөдөлмөр эрхэлж байгаа бус, иргэний эрх зүйн гэрээгээр ажил, үүрэг гүйцэтгэж байгаа иргэд, олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол олон улсын байгууллагын хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрт ажиллаж байгаа иргэдийг нийгмийн даатгалд заавал хамруулахаар болсон.

48. Тэтгэврийн олон давхаргат тогтолцоог нэвтрүүлэх, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид зэрэг тогтвортой бус орлоготой хэсгийг тэтгэврийн тогтолцоонд хамруулах зорилгоор Суурь тэтгэврийн тухай, Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн даатгалын тухай зэрэг хуулийн төслийг боловсруулаад байна.

49. Нийгмийн халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж, хөнгөлөлт, амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээнд хамрагдах эрх, иргэнийг тодорхойлох үүрэг бүхий амьжиргааг дэмжих зөвлөл бүх сум,

хороонд ажиллаж байна.

50. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасны дагуу ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа бол 18 хүртэл насны хүүхэд, тэтгэврээс өөр орлогогүй иргэн, хүүхдээ 2, ихэр бол 3 нас хүртэл өсгөн бойжуулж байгаа эх/эцэг, хугацаат цэргийн албан хаагч, мөн Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан иргэний эрүүл мэндийн даатгалыг төр хариуцах болов.

51. Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрх. Хүн амд өвчнөөс урьдчилан сэргийлэх, гаж зуршлаас ангид байх, боловсрол олгоход чиглэсэн өөрчлөлтийг Засгийн Газрын Тусгай сангийн тухай хуульд /2010 онд/ оруулснаар Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгө нь архи, согтууруулах ундааны онцгой татварын 1 хувь, эмийн импортын болон нэмэгдсэн өртгийн албан татварын 2 хувь, тамхины онцгой албан татварын 2 хувиас бүрдэх болов. Ингэснээр эрүүл мэндийг дэмжих сангаас зарцуулах хөрөнгийн хэмжээ нэмэгдэж, хүн амд чиглэсэн эрүүл мэндийн сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа өргөжлөө.

52. Сурч боловсрох эрх. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгодог. Хүн бүрт боловсролыг адил, тэгш олгохын тулд онцгой анхаарал хандуулж, 2000 оноос эхлэн дотуур байрны хүүхдийн бүх зардлыг төрөөс бүрэн хариуцах, нийгмийн эмзэг бүлгийн өрхийн хүүхдийн хичээлийн хэрэгсэл, сурагчийн дүрэмт хувцсыг буцалтгүй тусламж болгон олгох, 2009 –2010 оны хичээлийн жилээс эхлэн бага ангийн хүүхдийн сурах бичгийг төрөөс үнэ төлбөргүй эзэмшүүлэх, мөн “Үдийн цай” хөтөлбөрийг өргөжүүлэн, “Үдийн хоол” хөтөлбөр болгох үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Монгол Улсын 21 аймгийн төв болон 331 сум, Улаанбаатар хотын дүүрэг бүрт Насан туршийн боловсролын “Гэгээрэл” төв үйл ажиллагаа явуулж байна.

53. Шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрх. Иргэд төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг 18 наснаас эдэлнэ. УИХ 2011 онд Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийг баталснаар сонсогчийн бүртгэх, санал авах, үр дүнг нэгтгэх, хянах сонгуулийн үйл ажиллагааг илүү шуурхай явуулах, сонгуулийн автоматжуулсан систем ашиглах эрх зүйн орчинг бүрдүүлсэн. Үүний хамт сонгогчдын нэрсийн жагсаалт үйлдэх, хянах, нийтэд танилцуулахад холбогдох хуулийн зүйл, заалтыг шинэчлэв. Мөн гадаадад амьдарч байгаа 18 нас хүрсэн Монгол Улсын иргэн саналаа өгөх боломж бүрдсэн.

54. Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрх. Монгол Улсад иргэний нийгмийн байгууллага нь нам, төрийн бус байгууллага гэсэн хоёр хэлбэрээр хөгжиж байгаа бөгөөд эдгээрийг байгуулах, бүртгэх эрх зүйн зохицуулалт нь хуульчлагдсан байдаг.

55. Шашин сүм хийдийн харилцааг хуулиар зохицуулдаг ба төр шашин тус тусын хэрэгт үл оролцох зарчим, иргэдийн шүтэх, эс шүтэх эрх чөлөөг баталгаажуулж, шашны урсгалууд орж ирэх нөхцөлийг хангасан болно.

56. Улс төрийн нам байгуулахад хуулийн дагуу 30 хоногийн дотор бүртгэнэ. Иргэний нийгмийн байгууллага дотроос улс төрийн нам, үйлдвэрчний эвлэл тусгай хуулийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг.



57. Улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль 2011 онд батлагдсан. Энэ хуулиар эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйсийн шинжээр ялгаварлан гадуурхах явдлыг арилгах, улмаар улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын харилцаа, гэр бүлд жендерийн тэгш байдлыг хангах эрх зүйн зохицуулалтыг бий болгосон.

58. Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрх. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй. Иргэдийн санал, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх чиг үүрэг 11–11 тусгай дугаарын үйлчилгээ, мөн мессеж, интернетийн веб хуудсыг үндэсний хэмжээнд 2012 оноос ажиллуулж байна.

59. Халдашгүй, чөлөөтэй байх эрх. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 8 дугаар бүлэг сэжигтэнг баривчлах үйл ажиллагааг зохицуулсан байна. Энэ бүлэгт сэжигтэн оргон зугтахыг завдсан, эсвэл хүнд, онц хүнд гэмт хэрэгт сэрдэгдэх хангалттай баримт байгаа бол түүнийг баривчлаж болох ба хэрэг бүртгэгч мөрдөн байцаагч нь сэжигтнийг баривчлах тухай тогтоол үйлдэж прокурорт танилцуулах ба прокурор нь шүүхэд танилцуулж шийдвэрлэхээр заажээ.

60. Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тайланд “..2008–2010 оны судалгаагаар 630 хүнийг хойшлуулшгүй үндэслэлээр баривчилсныг шүүхэд мэдэгдээгүй байна гэсэн дүгнэлтэд хүрч байна. Энэ нь нийт баривчлагдсан хүний 34 хувийг эзэлж байх бөгөөд тэдний эрх, эрх чөлөө ямар үндэслэлээр хязгаарлагдаж байгааг шүүх хянах боломжгүй болж байна” гэж дурджээ.

61. Шүүх 2013 эхний хагас жилд эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58 ба 59 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 421 сэжигтнийг баривчлах тухай материалыг хүлээн авч, 384 сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгож, үлдсэнд зөвшөөрөл олгохоос татгалзсан байна.

## **2. Хүний эрхийн гэрээ, конвенциудын заалтыг үндэсний эрх зүйн тогтолцоонд нийцүүлсэн байдал**

62. Хүний амьд явах эрхийг ноцтойгоор зөрчсөн “2008 оны долдугаар сарын 1–ний үйл явдал”–ын сургамжид үндэслэн, хүний эрх, эрх чөлөөг хуулиар хязгаарлах, нөгөө талаар хүний эрхийг ямар ч тохиолдолд үл хөндөх Монгол Улсын Үндсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэх механизмыг Онц байдлын тухай болон Дайчилгааны тухай, Хохирогчид нөхөн төлбөр олгох тухай зэрэг хуулиудын шинэчилсэн өөрчлөлтөд тусгасан болно. Монгол Улсын нэгдэн орсон гэрээнүүдэд үндэсний хууль тогтоомж хэрхэн нийцэж байгааг судалсны үр дүнд Эрүү, Эрүүгийн байцаан шийтгэх, Авилгын тухай болон Эрүүгийн шүүхийн тухай хуулиудыг Ромын дүрэм, Авилгын эсрэг Конвенц, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ–ын Конвенц /Палермо, түүний протокол/, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг Конвенциудад нийцүүлэн өөрчлөхөөр ажиллаж байна.

63. Мөн Улсын Дээд Шүүхийн 2008 оны 2 дугаар сарын 28 –ны өдрийн 09 дүгээр тогтоолоор “Монгол Улсын олон гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн

зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай” тайлбар батлагдан гарчээ.

**Шүүх, төрийн захиргааны байгууллагуудын хүний эрхийн асуудалд нөлөөлөх байдал, хүний эрх хууль бусаар зөрчигдсэн хүн нь нөхөн олговор авах боломжтой эсэх**

64. Монгол Улсын Засгийн Газар нь хүний эрхийг шүүх, төрийн захиргааны байгууллагад зөрчих, эрхэд халдсан аливаа үйлдлээс урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

65. “Гэрч, хохирогчийн хамгаалах тухай” хуулийн 26 дугаар зүйлд “Гэмт хэргийн хохирогчид Засгийн Газрын Тусгай сангийн тухай хуулийн 21 дугаар зүйлд заасан журмын дагуу нөхөн төлбөр олгоно” гэж заасан бол Засгийн Газрын Тусгай сангийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд, “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан” гэсэн хэсэг орсон болно. Уг хуулийн энэ зүйлд тухайн сангийн эх үүсвэр, сангийн хөрөнгийг зарцуулах гэмт хэргийн төрөл, зардлын нэр төрөл, нөхөн төлбөрийн хэмжээ зэрэг харилцааг зохицуулж өгсөн.

66. “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай” хуулийг УИХ 2013 онд анх удаа баталсан бөгөөд энэ хуулийн зорилт нь гэмт хэрэг хянан шийдвэрлэх явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх эрх зүйн үндсийг тогтооход оршиж байна. Энэ хууль батлагдсанаар Монгол Улсад гэмт хэргийн гэрч, хохирогчийг хуулийн хүрээнд аюулгүй байдлыг нь хамгаалах, төрөөс дэмжлэг, туслалцаа үзүүлэх, хохирогчид нөхөн төлбөр олгох зэрэг харилцааны зохицуулалтын механизмыг улам боловсронгуй болгох боломж бүрдсэн.

**Дөрөв. Үндэсний түвшинд хүний эрхийг дээдлэх хүрээ**

**Монгол Улсын Хүний эрхийг хангах байгууллагууд, эдгээрийн үйл ажиллагаа**

67. Монгол Улсын Их Хурал 2010 онд Хүний Эрхийн дэд хороо байгуулсан бөгөөд энэ дэд хороо нь хүний эрх, эрх чөлөөний баталгаа, өршөөл, цагаачлад, иргэний харьяаллын асуудлыг хариуцаж байна. Мөн Их Хурлын харьяанд Хүний Эрхийн Үндэсний Комисс үйл ажиллагаа явуулж, Монгол Улсад хүний эрхийн нөхцөл байдлын талаар тайлан илтгэлээ жил бүр УИХ–д танилцуулдаг. Хүний Эрхийн Үндэсний Комиссийн тухай хуулийн 3.1–д “Комисс нь Монгол Улсын Үндсэн Хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхиүлэн дэмжих байгууллага мөн” гэж заажээ.

68. ХЭҮК 3 гишүүнээс бүрдэнэ. Комиссийн гишүүн нь хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, хүний эрхийн асуудлаар зохих мэдлэг, туршлагатай, ял шийтгэлгүй, 35 нас хүрсэн, Монгол Улсын иргэн байна. Комиссийн гишүүнийг Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Улсын Дээд Шүүхийн саналыг үндэслэн Улсын Их Хурлын дарга Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал 6 жил, Комиссын даргыг Улсын Их Хурлын дарга санал болгосноор Комиссийн гишүүдээс Улсын Их Хурал 3 жилийн хугацаагаар тус тус томилдог. Комиссийн ажлын алба нь 23 хүнтэй, 21 аймагт

төлөөлөгчтэй ажиллаж байна.

69. Хуульд заасны дагуу Комиссийн үйл ажиллагаанд туслах чиг үүрэг бүхий, хүний эрхийн талаар идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн Орон тооны бус зөвлөл ажилладаг. Зөвлөл нь Комиссийн үйл ажиллагаанд олон талт төлөөллийг хангах чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Анхны орон тооны бус зөвлөл 2002 оны 3 дугаар сарын 4–ний өдөр байгуулагдаж, бүрэлдэхүүнд нь Монголын Эмнести Интернейшнл, Хүчирхийллийн эсрэг Үндэсний Төв, Монголын Хүний эрхийн Төв зэрэг 11 байгууллагын төлөөлөл ажиллаж байсан бол 2014 оны байдлаар 19 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

70. ХЭҮК 2012 онд 428.8 сая төгрөг, 2013 онд 554.9 сая төгрөг, 2014 онд 902.5 сая төгрөгийн төсөвтэй үйл ажиллагаа явуулж байна. Төсвийг 1/ Хүний эрхийн асуудлаар шалгалт явуулах, судалгаа хийх, 2/ Хүний эрхтэй холбоотой аливаа асуудлаар зөвлөмж, шаардлага гаргах, 3/ Хүний эрхийн зөрчлийн тухай гомдол шийдвэрлэхтэй холбоотой үйл ажиллагаа, 4/ Хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа, 5/ Хууль тогтоох, хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын хүний эрхийн сургалт, 6/ Албан боловсрол болон бусад хэлбэрийн хүний эрхийн сургалтыг зохион байгуулах, 7/ Олон нийтэд чиглэсэн хүний эрхийн сурталчилгаа, 8/ Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, 9/ Дотоод хамтын ажиллагаа гэсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд зарцуулж, гүйцэтгэлийн үр дүнг жил бүр тайлагнаж байна.

71. Ерөнхий сайд болон Засгийн Газрын гишүүн, сайдаар удирдуулсан Жендерийн тэгш байдлын Үндэсний зөвлөл, Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөл, Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороо, Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөл, Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөл зэрэг иргэдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиг үүрэгтэй орон тооны бус үндэсний бүтэц, ажлын албад үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж байна.

72. Монгол Улсын Жендерийн Үндэсний Хороо 2005 оноос хойш Жендерийн тэгш байдлыг хангах тухай хуульд заасны дагуу Ерөнхий сайдаар ахлуулан үйл ажиллагаа явуулж байна. Үндэсний хороо нь Засгийн Газрын гишүүд, төрийн болон иргэний нийгмийн төлөөлөл бүхий өргөн бүрэлдэхүүнтэй бөгөөд орон нутагт салбар зөвлөлтэй болно.

73. “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” хуульд заасны дагуу Хүүхдийн төлөө Үндэсний Зөвлөл ажилладаг. Энэ зөвлөлийн 70 гаруй хувь Засгийн газрын гишүүд, сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга, 30 орчим хувь нийгэм, соёлын зүтгэлтнүүд болон хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон үндэсний байгууллагын төлөөлөл байдаг.

74. Засгийн Газар, ХЭҮК нь НҮБ, түүний төрөлжсөн байгууллага, бусад олон улсын болон бүс нутгийн, гадаад орны холбогдох байгууллагуудтай хүний эрхийг хэрэгжүүлэх, түүнтэй хамааралтай гэрээ, хэлэлцээрийг байгуулах, хэрэгжүүлэх, туршлага солилцох талаар өргөн хүрээнд хамтын ажиллагаа хөгжүүлж байна.

75. НҮБ–ын Хүний Эрхийн Зөвлөлөөс бүх гишүүн орны хүний эрхийн төлөв байдлыг 4 жил тутам дүгнэн хэлэлцдэг шинэ механизм болох Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг /Universal Periodic Review/ –ээр Монгол Улсын Хүний эрхийн

төлөв байдлын үндэсний анхдугаар илтгэлээ 2010 онд хүргүүлж, ХЭЗ–ийн чуулганаар хэлэлцүүлсэн. Үндэсний илтгэлт хэлэлцүүлсэнтэй холбогдуулж НҮБ–ын ХЭЗ–өөс гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх үүднээс Засгийн Газар 2011 оны 11 дүгээр сард “2011–2014 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”–г 159 дүгээр тогтоолоор баталсан. Төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлсэн тухай Засгийн газрын дунд хугацааны тайланг 2014 оны тавдугаар сард НҮБ–д хүргүүлсэн.

76. НҮБ–ын болон бүс нутаг, гадаад улс орнуудын хүний эрхийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа хөгжүүлэх, хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих, мэргэжлийн чадавхиа бэхжүүлэх зорилтын хүрээнд НҮБ–ын Хүний эрхийн Дээд Комиссарын газар, Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үндэсний байгууллагуудын Олон Улсын Зохицуулах Хороо, Ази Номхон Далайн бүс нутгийн Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Чуулгантай идэвхтэй хамтран ажиллаж, тодорхой төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, тэдгээр байгууллагаас 2010–2013 оны хооронд зохион байгуулсан бүх уулзалт, хуралдаанд оролцож ирлээ.

77. Катар Улсын Доха хотод болсон Ази Номхон далайн 2013 оны чуулганы /АНДЧ/ 18 дахь бага хуралд Үндэсний комиссийн төлөөлөл оролцож, уг хурлаас АНДЧ–ны 20 дахь удаагийн хурлыг Монгол Улсад Комисс зохион байгуулсан ба Үндэсний комиссийн дарга нь АНДЧ–ны дэд даргаар томилогдсон байна.

78. Хүний эрхийн үндэсний байгууллагуудтай харилцаа холбоо тогтоон, туршлага солилцох үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүднээс Шинэ Зеланд, БНСУ, Австрали, ХБНГУ зэрэг улс орны ХЭК–той хамтын ажиллагаагаа хөгжүүллээ.

### **Хүний эрхийн холбогдолтой актуудыг олон нийтэд түгээх, сурталчлах тогтолцоо**

79. Хүний Эрхийн Үндэсний Комиссийн тухай Монгол Улсын хуульд заасны дагуу Комисс хүний эрхийг таниулан ойлгуулах, хүний эрхийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн сурталчилгааны ажил тухайлбал, цахим хуудсаар дамжуулан мэдээлэл түгээх, улирал тутмын мэдээллийн хуудас гаргах, “Хүний эрх” сэтгүүл, Хүний эрхийн тодорхой асуудлаар хэвлүүлсэн эвхмэл хуудас, ном, товхимол, гэрэл зургийн үзэсгэлэн, гар зургийн уралдаан, нээлттэй өдөрлөг зохион байгуулах, мэдээлэл лавлагааны төв, телевиз, радиогийн нэвтрүүлэг, хүний эрхийн тухай шторк дамжуулах зэргээр олон нийтэд түгээж байна.

### **Хүний эрхийн боловсролын хөтөлбөр**

80. Монгол Улс Анх удаа 1997 онд их, дээд сургуулиудад мэргэжлийн чиглэлээр заавал үзэх хичээлийн жагсаалтад “Хүний эрхийн хичээл”–ийг 36 цагаар оруулж судлах болсон. Мөн Засгийн Газар 2011 онд “НҮБ–ийн Хүний эрхийн Зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2011–2014 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”–г батлахдаа ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт хүний эрхийн сэдвийг тусгах заалтыг тусгасан болно.

81. Хүний Эрхийн Үндэсний Комисс нь хуульд заасны дагуу дараах зорилтот бүлэгт хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг явуулж байдаг. Үүнд:

1. Иргэд, олон нийт;
2. Төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага, өөрийн удирдлагын

- байгууллага, төрийн албан хаагчид;
3. Шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, тахарын алба болон тэдгээр байгууллагын албан хаагчид;
  4. Хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, иргэний нийгмийн төлөөллүүд;
  5. Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хүүхдийн байгууллагын ажилтнууд;
  6. Хэвлэл, мэдээллийн байгууллага, сэтгүүлч, ажилтнууд;
  7. Эмэгтэйчүүд, оюутан, сурагч, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг болно.

82. Төрийн байгууллагын албан хаагчдын хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх, үйл ажиллагаандаа хүний эрхийн зарчмыг баримтлан ажиллах хандлагыг бий болгох зорилгоор “Хүний эрхэд суурилсан хандлага” сургалтын модулийг Боловсролын хүрээлэн, НҮБ–ын Хөгжлийн хөтөлбөрийн төсөлтэй хамтран боловсруулсан. Уг модуль нь зорилтот бүлгээс хамааран, тэдний хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, тодорхой хэсгүүдийг хэсэгчлэн авч ашиглах боломжтойгоос гадна сургагч багшид зориулсан мэдээллийг багтааснаараа бусад сургалтын модулиас онцлог юм. Энэ сургалтын модулийг ашиглан жил бүр зорилт бүлгийн хүний эрхийн сургалтыг зохион байгуулж байгаа бөгөөд хамрагдсан хүний тоо жил бүрээр доорх хүснэгт 1–д харууллаа.

*Хүснэгт 1. Хүний эрхийн сургалтад хамрагдагсдын тоо*

<b>Хүний эрхийн сургалт</b>		2009	2010	2011	2012	2013
<b>Төлөвлөгөөт сургалт</b>	Нийт цаг	234	147	149	75	174
	Нийт оролцогч	2415	2224	2012	387	1678
<b>Төлөвлөгөөт бус сургалт</b>	Нийт цаг	117	86	48	81	213

**Хүний эрхийн асуудалд төрийн бус байгууллагуудын оролцоо**

83. Төрийн бус байгууллагуудын анхны орон тооны бус зөвлөл 2002 оны 3 дугаар сарын 4–ний өдөр байгуулагдаж, бүрэлдэхүүнд нь Монголын Эмнести Интернейшнл, Хүчирхийллийн эсрэг Үндэсний Төв, Монголын Хүний эрхийн Төв зэрэг 11 байгууллагын төлөөлөл ажиллаж байсан бол эдүгээ 21 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэдэх Орон тооны бус зөвлөлийн дүрмийг 2013 онд шинэчилсэн.

84. Хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх тэтгэлэгт хөтөлбөрийг НҮБХХ–тэй хамтран жил бүр зохион байгуулж, төрийн бус байгууллагуудтай ажиллах хамтын ажиллагааны чиглэлээр нээлттэй хэлэлцэж тодорхойлдог боллоо.

**ХОЁР. ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ НҮБ–ЫН КОНВЕНЦИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ  
МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ТАВДУГААР ТАЙЛАН ИЛТГЭЛ**

**НЭГ. ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАНГАХ ЕРӨНХИЙ ОРЧИН, НӨХЦӨЛ**

**Хууль эрх зүйн зохицуулалт, шинэчлэлт, хандлага**

1. Монгол Улсын Их Хурал тайлант хугацаанд хүүхдийн эрхтэй хамааралтай 9 хууль шинээр, 13 хуульд нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулга оруулж батлан, нэг хуулийг хүчингүй болгожээ. Хүний хөгжлийн сангийн тухай, “Эвлэрүүлэн зуучлалын тухай”, “Гэрч хохирогчийг хамгаалах тухай” хууль нь хүүхдэд шууд үйлчлэх харилцааг зохицуулах бол бусад хууль нь шууд бус байдлаар үйлчилж байна.

Конвенцийн агуулга	Монгол Улсын шинэ болон шинэчилсэн хууль
Ерөнхий арга хэмжээ /4, 6, 42, 44–р зүйл /	“Төсвийн тогтвортой байдлын тухай” хууль 2010 Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, 2012 Монгол Улсын Шүүхийн тухай, 2012 Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, 2012 Хуульчийн эрх зүйн байдлын тухай, 2012 Засгийн газрын бүтцийн тухай, 2012 Тахарын албаны тухай, 2013 Цагдаагийн албаны тухай, 2013 Хүний хөгжлийн сангийн тухай, 2009
Үндсэн зарчим /2, 3, 6, 12–р зүйл/	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, 2011
Иргэний эрх чөлөө /7, 8, 13–17 болон 37 –ийн а заалт/	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, 2010 Жендерийн тэгш байдлыг хангах тухай, 2011 Жендерийн тэгш байдлыг хангах тухай хуулийг дагаж мөрдөх журмыг тухай, 2011
Гэр бүлийн орчин ба асран хамгаалал 5, 18, 9–11, 19–21, 25,27 болон 39	Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай, 2010 Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай, 2010 Агаарын тухай, 2012 Хог хаягдлын тухай, 2012 Усны тухай, 2012 Ус бохирдуулсны төлбөрийн тухай, 2012 Эвлэрүүлэн зуучлалын тухай, 2012 Хүнсний тухай, 2012 Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай, 2012

**ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ**

Конвенцийн агуулга	Монгол Улсын шинэ болон шинэчилсэн хууль
Эрүүл мэнд, нийгмийн халамж / 6, 18, 23, 24, 26 болон 27 –ийн 1–3–р заалт/	Эрүүл мэндийн тухай, 2011 Нийгмийн халамжийн тухай, 2012 Сэтгэцийн эрүүл мэндийн тухай, 2012 Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай, 2012
Боловсрол, чөлөөт цаг, соёлын арга хэмжээ /28, 29, 31–р зүйл/	Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай, 2011
Онцгой хамгааллын арга хэмжээ /22, 30, 38, 39, 40, 37 б, 32–36–р зүйл/	Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай, 2010 Хүн худалдаалахтай тэмцэх тухай /2012/ Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, 2013 Төлбөрийн чадваргүй яллагдагчдад хууль зүйн туслалцааны тухай, 2013 Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, 2013

2. 1996 онд батлаад хэрэгжиж байсан Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хууль 2013 онд хүчингүй болсон.

3. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль /ХЭХТХ хууль/–ийн хэрэгжилт үнэхээр хангалтгүй байгааг 2011 онд хийсэн тухайн хуулийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан баталсан. Энэ хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа гол шалтгаан нь Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль нь өөрөө хүүхдийн талаарх нийгэмд тулгамдсан асуудлыг зохицуулан шийдвэрлэх чадваргүй байна гэж дүгнэжээ. Цаашлаад хуульд заасан, хүүхдийн эрхийг хамгаалах үндсэн зарчмууд нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, Хүүхдийн Эрхийн тухай Конвенц, Монгол Улсын Үндсэн хуулийн агуулгад нийцсэн хэдий ч тунхагийн шинжтэй, хэрэгжүүлэх ба хэрэгжилтийг хянах арга замыг нарийн тодорхойлоогүй гэжээ. ХЭХ–ны зөвлөмж, хуулийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлангийн дүгнэлт, зөвлөмжид үндэслэн, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг шинэчлэн найруулах улмаар Хүүхэд хамгааллын тухай процессын шинэ хуулийн төслийг боловсруулж, өргөн барихаар ажиллаж байна. Түүнчлэн Хөдөлмөрийн тухай, Үндэсний их баяр наадмын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай зэрэг хуулийн шинэчилсэн найруулгын төслийг судалж, бэлтгэж байна.

**Хүүхэд хөгжил хамгааллын Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт**

4. Хүүхдийн Эрхийн Хорооны зөвлөмжийн дагуу Монгол Улсын Засгийн Газар 2010 онд төрийн болон иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл бүхий өргөн бүрэлдэхүүнтэй баг, бүрэлдэхүүнээр Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах Үндэсний хоёр дахь хөтөлбөр (2002–2010 он) –ийн үр дүнг үнэлэх ажлыг зохион байгуулав.

5. Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн

үр дүнг 4 бүлгийн 38 шалгуур үзүүлэлтээр үнэлж, түүнд үндэслэн, хүүхдийн эрхийн хэрэгжилтийн тухай мэдээллийн нэгдсэн санг бий болгох үндсийг бүрдүүлжээ. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг хүүхдийн эрхийн зарчимд үндэслэн, дараах байдлаар ангилан бүлэглэж тодорхойлсон байна: Хүүхдийн аюулгүй, эсэн мэнд амьдрах орчин /13 үзүүлэлт/, Хүүхдийн сурч, хөгжих орчин /9 үзүүлэлт/, Хүүхдийг дарамт, хүчирхийлэл, үл хайхрах ялгаварлаас хамгаалах орчин /7 үзүүлэлт/, Хүүхдийн оролцоог дэмжих орчин /9 үзүүлэлт/ гэсэн бүлэг байна.

6. Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах Үндэсний хоёр дахь удаагийн хөтөлбөр нь 2002 –2010 оны хооронд гурван үе шаттайгаар, нийт 311 зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлсэн бөгөөд эдгээрийн нийт биелэлт нь 74.6 хувьтай байна гэж дүгнэжээ.

7. Үндэсний хөтөлбөр хэрэгжсэн хугацаанд хүүхдийн эрүүл, аюулгүй амьдрах орчны үзүүлэлтүүд сайжирсан байв. 1000 хүнд ноогдох хүүхдийн эмчийн тоо үндэсний түвшинд 2001 онд 3.1 байсан бол 2005 онд 3.5, 2010 онд 5.0 болж өссөн байна. Нялхсын болон тав хүртэл насны хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөд 2001 онд 40.8 / 35 байсан бол 2010 онд 30,2 / 20.27 болж буурсан байна.



**ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ**

*Хүснэгт 1. Хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй орчны үр дүнгийн үзүүлэлт*

Шалгуур үзүүлэлт	Үндэсний суурь үзүүлэлт (2001)	Орон нутгийн суурь үзүүлэлт	Үндэсний завсрын үзүүлэлт (2005)	Орон нутгийн завсрын үзүүлэлт	Үндэсний эцсийн үзүүлэлт (2010)	Орон нутгийн эцсийн үзүүлэлт
1. Хүүхдийн эмч/өсвөр үеийнхний эмчийн тоо (1000 хүнд ногдох)	3.1	5.8	3.5	8.0	5	11.3
2. Нялхсын эндэгдэл (1000 амьд төрөлтөд)	30.2	20.42	20.8	19.30	19.70	20.27
3. Тав хүртэл насны хүүхдийн эндэгдэл (1000 амьд төрөлтөд)	40.8	20.09	26.1	19.91	23.5	21.31
4. Хүүхдийн 6 сар хүртэл хугацаанд дагнан эхийн сүүгээр хооллодог хувь	–	33.46	59	74.76	66	77.23
5. Тав хүртэлх насны хүүхдийн тураал/өсөлтийн хоцрогдлын хувь	11.9/29.9.	5.36/3.53	4.3/27.5	6.54/5.42	3.3/15.3	12.44/6.15
6. Эрүүл хот/Эрүүл мэндийг дэмжих байгууллагын тоо	0/25	0.5/153	1/100	2.5/281	3/200	5/385
7. Хүүхдэд ээлтэй эмнэлэг/Эрүүл мэндийг дэмжигч сургуулийн тоо	144/26	218/91	165/50	113/88	198/100	367/218

*Эх үүсвэр: Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах Үндэсний хөтөлбөр (2002–2010 он) –ийн үр дүнгийн үнэлгээний тайлан, ХТҮГ, 2012*

8. Хүүхдийн чанартай боловсрол, төлөвшлийн талаар дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт шалгуур үзүүлэлтийн үр дүн хангалттай сайн байв. Сургуулийн өмнөх насны хүүхдийн цэцэрлэгт хамрагдалт 2001 онд 34 хувь байсан бол 2010 онд 72 хувьд хүрсэн байв.

**ЗУРГАДУГААР БҮЛЭГ**

*Хүснэгт 2. Хүүхдийн боловсрол, төлөвшлийн үр дүнгийн үзүүлэлт*

Шалгуур үзүүлэлт	Үндэсний суурь үзүүлэлт (2001)	Орон нутгийн суурь үзүүлэлт	Үндэсний завсрын үзүүлэлт (2005)	Орон нутгийн завсрын үзүүлэлт	Үндэсний эцсийн үзүүлэлт (2010)	Орон нутгийн эцсийн үзүүлэлт
8. Сургуулийн өмнөх насны хүүхдийн цэцэрлэгт хамрагдалтын хувь	34.0	30.27	62.0	44.72	72.0	60.63
9. Бага боловсролын хамран сургалтын хувь	95.3	76.70	97.0	86.14	99.0	88.82
10. Суурь боловсролын хамран сургалтын хувь (бохир жингээр)	89.7	76.67	92.0	83.83	95.0	77.01
11. Суурь болон бүрэн дунд боловсролын хүйсийн харьцааны хувь	52.8/58.7	37.27/43.28	52.0/56.0	38.90/45.68	51.0/54.0	35.44/47.74
12. ЕБС-ийн ээлжийн итгэлцүүр	2.7	1.61	2.2	1.56	1.8	1.53
13. Интернэтэд холбогдсон сургуулийн хувь	55	6.58	75	15.61	95	43.14
14. ЕБС-ийн сурагчдын хичээлээс гадуурх сургалтад хамрагдалтын хувь	20	23.72	40	37.74	60	57.02
15. Чөлөөт цагийн танхимтай сургуулийн хувь	10	21.55	30	32.96	50	46.70
16. ЕБС-ийн сурагчдын соёл урлагийн үйлчилгээнд хамрагдалтын хувь	30	32	50	45	65	58

*Эх үүсвэр: Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах Үндэсний хөтөлбөр (2002–2010 он) –ийн үр дүнгийн үнэлгээний тайлан, 2012*

**ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ**

9. Хүүхдийн сурч, хөгжих орчны үзүүлэлт 2010 онд үндэсний хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын хамралт 72, суурь боловсролын хамралт 95 хувь байв.

10. Гэр бүлд түшиглэсэн хүүхэд хамгааллын зорилтыг дүгнэх шалгуур үзүүлэлтүүд нь хөтөлбөрийг боловсруулах шатанд тодорхойгүй байсан юм. Харин завсрын болон эцсийн шатанд нарийвчлан тодорхойлсон байна. Хүүхэд хамгааллын тогтолцоо хараахан бүрэн хөгжөөгүй, эрх зүйн болон үйлчилгээний хувьд шийдвэрлэх асуудлууд хөтөлбөр хэрэгжих хугацаанд үргэлжилсээр байсныг дахин нотолж байв.

*Хүснэгт 3. Хүүхдийн хамгааллын үр дүнгийн үзүүлэлт*

Шалгуур үзүүлэлт	Үндэсний суурь үзүүлэлт (2001)	Орон нутгийн суурь үзүүлэлт	Үндэсний завсрын үзүүлэлт (2005)	Орон нутгийн завсрын үзүүлэлт	Үндэсний эцсийн үзүүлэлт (2010)	Орон нутгийн эцсийн үзүүлэлт
Хүүхдийн төрсний гэрчилгээ олголтын хувь	96	90.25	98	90.24	97	91.81
Хүнд нөхцөл дэх хүүхдийн тоо /бууралтын хувь/	–	7.07	20	16.75	30	17.94
Нийгмийн цогц суурь үйлчилгээний хөтөлбөрт хамрагдсан аймаг, дүүрэг/ сумын тоо	7/10	11/12	10/20	19/19	30/50	40/40
Хүнд буюу тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн тоо / буурсан хувь/	–	8.07	50	70	95	57
Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүмүүсийн тоо /буурсан хувь–(10000 хүүхдэд ногдох)	–	6.57	5	10.59	10	13.06
Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тооны буурсан хувь–(10000 хүүхдэд ногдох)	–	2.14	20	6.18	30	13.77

*Эх үүсвэр: Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах Үндэсний хөтөлбөр (2002–2010 он) –ийн үр дүнгийн үнэлгээний тайлан, ХТҮГ, 2012*

11. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэн, хүүхэд хамгааллыг бэхжүүлэх асуудалд тэргүүлэх ач холбогдол өгөхийг тэмдэглэсэн байна. Түүний үр дүнд Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөл 2010 онд “Хүүхэд хамгааллыг бэхжүүлэх стратеги (2010–2015)”-ийг баталж, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 341 дүгээр тогтоолоор баталсан байна. Хүүхэд хамгааллыг бэхжүүлэх стратеги нь хүүхэд

бүрийг үл хайхрах, хүчирхийлэх, мөлжих явдлаас сэргийлэх, хамгаалах тогтолцоог хөгжүүлэх зорилгыг тавьсан бөгөөд дээрх зорилгыг хэрэгжүүлэх стратегийг томьёолжээ:

1. Хүүхэд хамгааллын удирдлага, санхүүжилтийг бэхжүүлэх,
2. Хүүхэд хамгааллын үйлчилгээ, зохицуулалтыг бэхжүүлэх,
3. Хүүхэд хамгааллын чадавхийг бэхжүүлэх зэрэг

Энэхүү стратегийг хэрэгжүүлэхээр 2012 оноос эхлэн жилд дунджаар 400–500 сая төгрөгийг улсын төсвөөс Хүүхдийн төлөө Үндэсний газрын төсөвт шинээр хуваарилан олгож байна.

### **Бие даасан хяналт**

12. ХЭҮК–ийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар гишүүний тоог нэмэгдүүлэхийг чармайсан боловч шийдвэрлэгдээгүй. Харин ХЭҮК–ийн ажлын алба болон орон нутагт ажиллах хүний нөөц бүрэлдэхүүн харьцангуй дээшилж, бүх аймаг, нийслэлд Хүний эрхийн комиссийн төлөөлөгчийг 2013 оноос ажиллуулж байна. Тайлант хугацаанд ХТҮГ хүүхдийн эрхийн хяналтыг сайжруулах зорилгоор өөрийн стратеги, төлөвлөгөөний дагуу орон нутагт хүүхдийн хамт олноос нэр дэвшин итгэл хүлээж сонгогдсон “Хүүхдийн элч” ийг сайн дураар ажиллуулах хэлбэрийг дэмжиж, Улсын хэмжээнд 300 шахам “Хүүхдийн элч” ажиллаж байгаа ч тэднийг урамшуулах, дэмжих механизм тогтворжиж амжаагүй, санаачилга төдий хэвээр байна.

13. “Хүүхдээс гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, хуваарилах, шийдвэрлэх журам”–ыг 2012 оны долдугаар сарын 3–ны 22/45 хамтарсан тушаалаар Хүний Эрхийн Үндэсний Комиссийн дарга, Хүүхдийн төлөө Үндэсний Газрын дарга нар баталсан байна. Журамд хуулийн дагуу амаар, бичгээр гаргаж байгаа өргөдөл, гомдлыг хүлээн авах, бүртгэх, тэмдэглэх, хүлээх авах боломжгүйг нь гурван хоногийн дотор зохих газарт шилжүүлэх, хүлээн авсан өргөдөл, гомдлыг 30–60 хоногийн дотор багтаан шийдвэрлэх, хариу өгөх ажиллагааны талаар тусгажээ.

14. Хүүхдийн эрхийг хамгаалах төв, орон нутгийн төрийн байгууллагууд хамтран “Мэдээлэл хүргүүлэх журам”–ын тухай ХЭК–ийн Нэмэлт Протоколд нэгдэн орох бэлтгэл хүрээнд Хүүхдээс өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх байдалд үнэлгээ хийсэн. Хүүхдийн өргөдөл, гомдлын талаар хийсэн судалгаагаар хэн нэгэнд өргөдөл гомдол гаргах талаар ойлголт мэдлэгтэй эсэх асуултад 6–9 насны хүүхдийн 21% нь ойлголт мэдлэгтэй, 10–14 насны хүүхдийн 40,1 хувь ойлголт мэдлэгтэй, 14–18 насны хүүхдийн 63,6 хувь нь ойлголт мэдлэгтэй байгаа дүн гарсан байна. Өргөдөл, гомдол гаргасан хүүхдийн хувьд асуудлаа шийдвэрлүүлсэн байдал нь 6–9 насны хүүхдийн 31% нь шийдвэрлүүлж чаддаг, 44% асуудлаа шийдвэрлүүлж чаддаггүй, 25% нь зарим тохиолдолд шийдвэрлүүлдэг бол, 10–14 насны хүүхдийн 51% нь шийдвэрлүүлж чаддаг, 13% нь шийдвэрлүүлж чаддаггүй, 21% нь заримдаа шийдвэрлүүлдэг, 15% нь асуудал тавьж байгаагүй гэсэн хариулт өгчээ. Иймд хүүхэд өөрөө болон асран хамгаалагчтай хамтран, эсвэл хэн нэгэн төлөөлөн зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар өргөдөл гомдол гаргах зөвлөмж, аргачлалыг өргөн түгээж, хүүхдийн эрхтэй холбоотой өргөдөл гомдолд хүндэтгэлтэй хандах шаардлагатай байна.

**Хүүхдийн төлөө байгууллагын тогтолцоо, бүтэц,  
үйл ажиллагаа**

15. Хүүхдийн Эрхийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар заалтын дагуу Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөл (энэ талаар өмнөх 3 ба 4 дүгээр илтгэлийн 40 дүгээрт тайлбарласан) болон аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр болсон хурлыг нь тогтмолжуулахыг эрмэлзэж, хянаж ажилласан байна. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр хурал нь тогтмолжсон Хүүхдийн төлөө зөвлөлийн эзлэх хувь 2010 онд–74 байсан бол 2013 онд 76 хувь болжээ. Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөлийн гишүүдийн оролцоо, нөлөөг дайчилж, хүүхдийн хөгжил хамгааллын асуудлаар хамтын ажиллагаа, салбар дундын зохицуулалтыг хангах, хүүхдэд чиглэсэн салбарын төсвийн хуваарилалтыг нэмэгдүүлэхэд анхаарч байна.

16. Засгийн Газар 2012 онд хүүхдийн хөгжил, хамгааллын асуудлыг гэр бүл, хүн ам зүйн бодлоготой уялдаатай хэрэгжүүлэх зорилгоор Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлж, ХАХНХЯ–ны харьяанд ХТҮГ–ыг ажиллуулж байна. Энэ агентлаг анх 1991 онд Боловсролын Сайдын дэргэд байгуулагдсан бөгөөд 1992–1996 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны, 1996–2000 онд Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны, 2000 –2004 онд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны, 2004–2012 онд Монгол Улсын Шадар Сайдын дэргэд тэдгээрийн хамаарах эрх мэдлийн хүрээнд тус тус ажиллаж байв.

17. Агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг 2006 он хүртэл Засгийн Газар, түүнээс хойш салбар эрхэлсэн Сайд нь эрх хэмжээнийхээ хүрээнд батлах болсон. Одоо дагаж мөрдөж байгаа ХТҮГ–ын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг 2012 онд ХАХНХ–ын Сайд баталсан бөгөөд агентлаг одоо Хүүхэд, гэр бүл хөгжлийн газар, Хүүхэд хамгаалал, үйлчилгээний газар, Тамгын газар /дотроо Олон нийттэй харилцах, Гадаад хамтын ажиллагаа, нийтлэг үйлчилгээний хэлтэстэй/, Мэдээлэл, судалгаа мониторингийн газар гэсэн дөрвөн үндсэн нэгж бүхий бүтэцтэй, 27 орон тоотой ажиллаж байна. Хэрэгжүүлэгч чиг үүргийн агентлаг бөгөөд хүүхдийн эрхийн салбар дундын зохицуулалтыг хангах асуудал бусад ижил төсөөтэй төрийн байгууллагуудын нэгэн адил төвөгтэй хэвээр байна.

18. Хүүхдийн төлөө байгууллагуудад 2012 оноос хүүхэд хамгааллын асуудлаар дагнасан газар, нэгжийг үндэсний болон орон нутгийн түвшинд байгуулж, хүүхдийн хамгааллын бодлого, журам, үйлчилгээний төрөл, хэлбэр, дүрэм журам, стандарт зэргийг боловсруулан, хэрэгжүүлж эхэлсэн нь хүүхдийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлэх шинэ эхлэл юм. Хэдийгээр хүүхэд хамгааллын үйлчилгээ үндэсний хэмжээнд цогц байдлаар хөгжихөд цаг хугацаа, туршлага, хөрөнгө төсөв шаардагдахаар байгаа ч эхний зарим алхам үр дүнтэй, нэн шаардлагатай болох нь үнэлэгдэж байна.

19. Хүүхдийн төлөө салбарт 2013 оны байдлаар 617 хүн ажиллаж байна. Энэ салбарт 2012 онд хийсэн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн дараа ч ажиллагчдын тоо хэвээр байна. /Хүснэгт 4/ Гэр бүлийн хөгжил, хүүхдийн салбарын ажиллах хүн хүчний тоо:

**ЗУРГАДУГААР БҮЛЭГ**

<b>Албан тушаалаар</b>	<b>2009</b>	<b>2010</b>	<b>2011</b>	<b>2012</b>	<b>2013</b>
Удирдах ажилтан	34	29	29	29	29
Гүйцэтгэх ажилтан	309	233	233	233	233
Үйлчилгээний ажилтан	174	150	156	156	156
Гэрээт ажилтан	175	189	199	199	199
<b>Хүүхдийн эрхийг хамгаалах салбар</b>	<b>692</b>	<b>601</b>	<b>617</b>	<b>617</b>	<b>617</b>

*Эх үүсвэр: Улсын төсвийн 2013 оны танилцуулга, СЯ.*

20. Эдийн засгийн хямралыг даван туулах Засгийн Газрын арга хэмжээний дагуу төрийн байгууллагуудын зохион байгуулалтын бүтцийг оновчтой болгох, давхардлыг арилгах зорилгоор хийсэн өөрчлөлтөөр 2010 онд хүүхдийн байгууллагын ажилтны тоо 90 орчим хүнээр буурчээ.

21. 2011 оноос эрхэлсэн Сайдын шийдвэрээр хүүхэд, өсвөр үеийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх НҮБ-ын нийтлэг зарчим, жишиг дүрмийг хэрэгжүүлэх, хууль зөрчсөн болон хэргийн гэрч, хохирогч болон хүүхдийн эрх ашгийг хамгаалах, хүмүүжлийн чанартай арга хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор аймаг, нийслэл, дүүрэгт Хүүхдийн Хууль зүйн хороог /аймаг, дүүрэгт орон тооны бус хэлбэрээр/ зохион байгуулах жишиг дүрмийг батлан хэрэгжүүлэв. Энэ дүрмийн дагуу аймаг, дүүргийн Хүүхдийн Хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, дүрэм, зардлыг тухайн орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталж, Засаг дарга удирдан, бүрэлдэхүүнд нь ИТХ, Засаг даргын тамгын газар, шүүх, прокурор, цагдаа, өмгөөлөл, шийдвэр гүйцэтгэлийн байгууллага, иргэд олон нийт зэрэг бүх талын төлөөлөл орж байна.

22. ХАХНХЯ-аас 2012 онд хүүхдийн зориулалттай барилга, байгууламж, материаллаг баазын зориулалт, ашиглалтын байдалд улсын хэмжээний үзлэг, тооллого явуулж, нийт 151 барилга, байгууламжийг бүртгэн, зориулалтын дагуу ашиглах, аюулгүй байдлыг хангах, нэмж өргөтгөх, засвар үйлчилгээг сайжруулах нэгдсэн төлөвлөгөө, чиглэл гаргаад ажиллаж байна.

**Төсөв, хөрөнгийн хуваарилалт, зарцуултын байдал**

23. Монгол Улс нь 2013 оноос эхлэн Төсвийн шинэ хуулийн дагуу хөтөлбөрийн төсөвлөлт буюу төсвийн үр дүнг тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээгээр төсвийг хуваарилж, гүйцэтгэлд хяналт тавих тогтолцоонд шилжсэн.

24. Эдийн засгийн хөгжлийн гадаад, дотоод эрсдэл, хүчин зүйлийн нөлөөг бууруулах, төсвийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг 2010 онд УИХ баталсан. Ингэснээр нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцох, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний /ДНБ/ хоёр хувиас илүүгүй алдагдалтай байх, нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн

**ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ**

бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ –ний дунджийн их үзүүлэлтээс хэтрэхгүй байх, улсын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон ДНБ–ний 40 хувиас хэтрэхгүй байх зэрэг тусгай шаардлагыг хангасан байх зохицуулалттай боллоо. Эдгээр зохицуулалт нь төсвийн тогтвортой байдлыг хангах боломжийг бүрдүүлсэн болно.

25. Үндэсний статистикийн хорооны мэдээгээр Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2011 онд 17.3 хувь, 2012 онд 12.3 хувь, 2013 онд 11.6 хувь байсан байна. Түүнчлэн, ДНБ оны үнээр 2008 онд 6.6 их наяд, 2013 онд 19.1 их наяд төгрөг байсан байна. Иймд тайлангийн 32 дахь хэсэгт заасан тоон мэдээллийг ҮСХ–ны тоотой нийцүүлэн өөрчлөх шаардлагатай гэж үзэж байна.

*Хүснэгт 9. Монгол Улсын эдийн засгийн үндсэн үзүүлэлт /сая төгрөгөөр/*

<b>Үзүүлэлт</b>	<b>2008</b>	<b>2009</b>	<b>2010</b>	<b>2011</b>	<b>2012</b>	<b>2013</b>
ДНБ, оны үнээр	6,555,569	6,590,637	9,756,588	13,173,763	16,688,419	19,118,002
ДНБ, 2005 оны зэрэгцүүлэх үнээр	3,963,960	3,913,673	4,162,784	4,891,840	5,498,482	6,144,175
ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр	–	–	9,756,588	11,443,578	12,853,406	14,350,131
Цэвэр өсөлт, бууралт	8.9	–1.3	6.4	17.3	12.3	11.6

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

26. Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2011 онд 17,5 хувь хүрч түүнээс хойш дунджаар 13 –14 хувийн тогтмол өсөлт гарч байв. Энэ хугацаанд дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 6,4 их наядаас 20,5 их наяд төгрөгт хүрсэн.

27. Хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжлийг дэмжих хөтөлбөрийн төсөв нь Засгийн Газрын шинэ бүтцийн дагуу 2012 оноос ХАХНХ–ын Сайдын төсвийн багцад тусгагдах боллоо. /Хүснэгт 5–ыг харна уу./

*Хүснэгт 10. Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын салбарын төсөв /сая.төг/*

<b>Хөтөлбөрийн нэр</b>	<b>2011</b>	<b>2012</b>	<b>2013</b>	<b>2014</b>	<b>2015</b>
	<b>гүйцэтгэл</b>	<b>гүйцэтгэл</b>	<b>гүйцэтгэл</b>	<b>батлагдсан төсөв</b>	<b>төсвийн төсөл</b>
<b>Нийт дүн</b>	<b>343,872.8</b>	<b>474,886.0</b>	<b>350,297.3</b>	<b>414,334.3</b>	<b>393,259.4</b>
Хөтөлбөр 1. Нийгмийн халамжийн үйлчилгээ	150,272.4	191,433.5	72,948.0	80,224.5	58,814.5
Хөтөлбөр 2. Нийгмийн даатгалын үйлчилгээ	187,066.8	272,760.2	264,599.5	320,162.9	320,139.7

**ЗУРГАДУГААР БҮЛЭГ**

Хөтөлбөр 3. Хүүхдийн эрхийн хамгаалал, хөгжлийг дэмжих үйл ажиллагаа	5,502.0	8,320.6	10,408.9	11,582.9	11,903.8
Хөтөлбөр 4. Нийгмийн хамгааллын бодлого, удирдлага	1,031.6	2,371.7	2,341.0	2,364.0	2,401.4

*Эх үүсвэр: Улсын төсвийн 2013 оны танилцуулга, СЯ*

28. Хүүхдийн байгууллагын 2013 оны батлагдсан төсвийн 46 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэл, 52.7 хувийг бараа үйлчилгээний зардал, 1.3 хувийг татаас шилжүүлэг эзлэж байна.

*Хүснэгт 11. Хүүхдийн байгууллагын 2012–2015 оны төсвийн мэдээлэл /сая төг./*

Хүүхдийн байгууллагын төсвийн бүрэлдэхүүн үзүүлэлт	батлагдсан төсөв				
	2011	2012	2013	2014	2015
I. НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,081.8	8,939.7	10,830.5	11,582.9	11,903.8
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	6,081.8	8,939.7	10,830.5	11,582.9	11,903.8
IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	6,081.8	8,939.7	10,830.5	11,582.9	11,903.8
Бараа, үйлчилгээний зардал	5,947.1	8,867.7	10,686.3	11,323.6	11,793.1
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,446.4	3,984.0	4,487.3	5,030.1	5,558.3
Ажил олгогчоос төлөх НДШ	268.9	437.7	490.4	553.7	611.4
Бараа, үйлчилгээний бусад зардал	3,085.2	4,446.0	5,708.6	5,739.8	5,623.3
Татаас ба урсгал шилжүүлэг	134.7	72.0	144.1	259.3	110.7

Боловсролын салбарын үйлчилгээний чанарыг сайжруулахад Монгол Улсын Засгийн Газар ихээхэн анхаарал тавьж ажиллаж байгаа бөгөөд үүний үр дүнд энэ салбарын төсөв 2015 он гэхэд 2–3 дахин өсөхөөр төлөвлөсөн байна:

*Хүснэгт 12. Боловсролын салбарын төсөв /сая төг./*

Хөтөлбөрийн нэр	2011	2012	2013	2014	2015
	гүйцэтгэл	гүйцэтгэл	гүйцэтгэл	батлагдсан төсөв	төсвийн төсөл
Нийт дүн	388,958.5	571,546.9	641,932.6	747,160.0	784,791.2
Хүүхдийн цэцэрлэг	103,343.1	164,747.8	192,858.5	221,380.8	247,560.7
Ерөнхий боловсролын сургууль	285,615.4	406,799.2	449,074.1	525,779.2	537,230.5

*Эх үүсвэр: Улсын төсвийн 2013 оны танилцуулга, СЯ*



30. Засгийн Газрын 2012 –2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт хот, хөдөөгийн ялгаатай байдлыг бууруулах олон зорилт, үйл ажиллагааг тодорхойлж хэрэгжүүлж байна.

31. Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалт 2013 онд 1,5 их наяд төгрөг, 2014 онд 1,6 их наяд төгрөг хүрсэн бөгөөд төсвийн хөрөнгө оруулалтын 80 орчим хувь нь хүн ам, иргэдийн амьдрах орчныг сайжруулахад чиглэж байна. Үүний дийлэнх нь авто зам, хүн амын усан хангамж, орон сууц, соёл, спортын үйлчилгээ, сургууль, цэцэрлэг, дотуур байр, эмнэлгийн барилга байгууламж болон үйлчилгээний байгууллагын барилга байгууламжийн их засварын хөрөнгө оруулалт эзэлж байна. Хүүхдийн төлөө Үндэсний газарт хүүхдийн амралт чөлөөт цагийн барилга байгууламж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сувилал, асран хамгаалах барилга шинээр барих, их засварт 2012 онд 18 тэрбум, 2013 онд 5 тэрбум, 2014 онд 9 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын төсвийг хуваарилжээ. Түүнчлэн хүүхдийн байгууллагын үйл ажиллагаанд хувийн хэвшил, иргэдийн дэмжлэг, нэмэгдэж байна. Цаашид энэ мэдээллийг нэгтгэх, хяналт тавих шаардлага урган гарч байна.


32. Боловсрол, хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжлийг дэмжих хөтөлбөрөөс бусад салбарын хувьд (эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, онцгой байдлын үйлчилгээ) хүүхдэд зориулах төсвийн тоо хэмжээг нарийвчлан тодорхойлох бололцоогүй хэвээр байна. Иймээс Сангийн яам, Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн, НҮБ-ын Хүүхдийн сан хамтран 2013–2014 онд нийгмийн салбарын төсвийн судалгааг улсын болон орон нутгийн түвшинд хийв. Энэ талаар мэдээллийг [www:\http: unicef.mn](http://www.unicef.mn) болон [pas.gov.mn](http://pas.gov.mn) хаягаас үзнэ үү. Судалгаагаар хүүхдэд зориулсан нийт зарлага ДНБ-ий 6 орчим хувьтай тэнцэж байгаа бөгөөд сүүлийн хэдэн жилд энэ дүн бараг тогтвортой байжээ. Төсвийн зарлагын тухайд 2008–2011 онд Монгол Улс нийт зарлагынхаа 16–19 хувийг хүүхдэд зарцуулсан аж. Энэ хувь сүүлийн хоёр жилд 14 хувь болж буурчээ. Хамгийн сүүлийн тоо баримтаас үзэхэд, нэг хүүхдэд ногдох зарлагын хэмжээ 2013 онд 617.03 ам.доллартай тэнцэж байв.

*Хүснэгт 13. Хүүхдэд зориулсан нийт хөрөнгө оруулалт, ДНБ-д эзлэх хувь ба төсвийн нийт зарлагад эзлэх хувиар (2008–2013)*

	2008	2009	2010	2011	2012	2013
Хүүхдэд зориулсан хөрөнгө оруулалт /ДНБ-д эзлэх хувиар /	5.56	5.00	6.08	6.88	6.30	5.99
Хүүхдэд зориулсан хөрөнгө оруулалт /төсвийн зарлага эзлэх хувиар/	18.99	16.32	19.74	18.82	14.93	14.19
Хүүхдэд зориулсан хөрөнгө оруулалт (сая ам. доллар)	287.52	228.55	406.9	533.26	662.01	621.34
Нэг хүүхдэд ногдох нийт зарлага / ам. Доллар/	272.53	220.38	398.09	539.37	657.48	617.03

*Эх сурвалж: Нийгмийн салбарын төсвийн шинжилгээ: Хүүхдэд зориулдаг хөрөнгө оруулалт, судалгааны багийн тооцоолол, 2014*


Зураг 1. Хүүхдэд чиглэсэн нийгмийн салбарын зарлага, 2003–2012



Эх сурвалж: Нийгмийн салбарын төсвийн шинжилгээ: Хүүхдэд зориулдаг хөрөнгө оруулалт, судалгааны багийн тооцоолол, 2014.

33. Ийм төрлийн шинжилгээ хийдэг бусад оронтой харьцуулахад хүүхдэд зориулсан хөрөнгө оруулалт ДНБ-д эзлэх хувиар дундаж үзүүлэлт болох 5 хувиас бага зэрэг өндөр байна (5.99 хувь), гэхдээ төсвийн зарлага (14.19 хувь) нь бусад орнуудын дундаж болох 16 хувиас доогуур байна. Хэдийгээр шинжилгээ хийсэн улс орнууд хоорондоо асар ялгаатай ч дээрх үзүүлэлт сонирхолтой суурь мэдээлэл юм. Тухайлбал, Өмнөд Америкийн олонхи улсын Засгийн Газрын төсөвт эзлэх хүүхдэд зориулсан хөрөнгө оруулалтын хувь нь Монголынхоос харьцангуй өндөр байна.

Зураг 4. Хүүхдэд зориулсан хөрөнгө оруулалт, ДНБ-д эзлэх хувь ба нийт төсөвт эзлэх хувь /сонгон авсан зарим оронд/



Эндээс харахад хүүхдэд зориулсан хөрөнгө оруулалт 2003 онд 89 тэрбум төгрөг байсан бол 2013 онд 1 их наяд төгрөг болж, сүүлийн арван жилд хөрөнгө оруулалт даруй 11.7 дахин өссөн дүр зураг ажиглагдаж байна. Тооцооллоос харахад 2003 онд Засгийн Газар хүүхдэд зориулан шууд 89.6 тэрбум төгрөг (буюу одоогийн ханшаар тооцоход 54.39

**ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ**

сая ам.доллар)<sup>1</sup> зарцуулсан байна. 2013 онд эдийн засаг, төсөв өсөхийг хэрээр хүүхдэд зарцуулсан хөрөнгө оруулалтын хэмжээ 1.05 их наяд төгрөгт (буюу 641.17 сая ам.доллар) хүрчээ.


*Хүснэгт 14. Хүүхдэд чиглэсэн хөрөнгө оруулалт салбараар, нэг хүүхдэд ногдох зардлаар*

	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Боловс- ролын салбарын зарцуулалт (тэрбум төгрөг)	72.26	88.48	97.98	125.63	168.28	268.28	274.39	318.58	388.96	571.55	655.47
Эрүүл мэндийн салбарын зарцуулалт (тэрбум төгрөг)	15.12	18.55	20.13	24.96	33.18	52.28	51.08	60.93	82.79	146.46	179.59
Нийгмийн хамгааллын салбарын зарцуулалт (тэрбум төгрөг)	2.27	2.43	2.36	2.98	4.67	5.90	4.36	11.84	19.09	11.20	13.59
Хүүхдийн мөнгө (тэрбум төгрөг)	0.00	0.00	40.90	37.77	38.22	37.98	37.60	120.19	253.74	192.38	168.60
<b>Нийт зарцуулалт (тэрбум төгрөг)</b>	<b>89.65</b>	<b>109.46</b>	<b>161.38</b>	<b>191.34</b>	<b>244.35</b>	<b>364.44</b>	<b>367.37</b>	<b>511.55</b>	<b>744.58</b>	<b>921.59</b>	<b>1,056.29</b>
0–19 насны хүн ам (мянга)	1,110.3	1,123.2	1,136.2	1,049.3	1,061.6	1,055.0	1,037.1	1,022.14	988.60	1,006.90	1007
Нэг хүүхдэд ногдох зарцуулалт (мянган төгрөг)	80.74	97.45	142.03	182.35	230.17	345.44	354.22	500.47	753.17	915.27	1,048.96

*Эх сурвалж: Нийгмийн салбарын төсвийн шинжилгээ: Хүүхдэд зориулдаг хөрөнгө оруулалт, судалгааны багийн тооцоолол, 2014*

<sup>1</sup> Үүнд Хүүхдийн мөнгө хөтөлбөр багтсан болно

Зураг 5. Хүүхдэд зориулсан нийт зарцуулалтад нийгмийн салбар тус бүрийн эзлэх хувь



Эх сурвалж: Нийгмийн салбарын төсвийн шинжилгээ: Хүүхдэд зориулдаг хөрөнгө оруулалт судалгааны багийн тооцоолол, 2014

#### Авилга, ашиг сонирхлын зөрчил, аудит, хяналт шалгалт

34. Авилгатай тэмцэх үйл ажиллагааны нэг чухал хэсэг нь төрийн албан хаагч жилд олсон нийт орлогынхоо эх үүсвэр, тоо хэмжээг Авилгатай тэмцэх газар /АТГ/-т нотлоход оршдог юм. АТГ 2009 онд 54000, 2010 онд 56000, 2011 онд 58000, 2012 онд 45000 төрийн албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авч, хяналт тавьж байна. Сүүлийн үед АТГ-ын мөрдөн шалгах ажиллагааны эрх зүйн орчин сайжирч байна.

35. Энэ газраас 2009 онд 2483, 2010 онд 8883, 2011 онд 11798, 2012 онд 18095 төрийн албан хаагчийг хамруулан, “Авлигын талаарх ойлголт, авлигын шалтгаан, хор хөнөөл”, “Авилгын эсрэг хууль тогтоомж”, “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь”, “Үндэсний шударга ёсны тогтолцоо” зэрэг сэдвээр сургалт зохион байгуулж, авилгыг үл тэвчих ёс зүйг төлөвшүүлэх ажлыг хийж байна.

36. Мөн ерөнхий боловсролын сургуулийн 3, 7, 8, 9 дүгээр ангид судлах “Иргэний боловсрол” хичээлийн сурах бичигт “Шударга ёс” сэдвээр агуулгыг нь баяжуулах судалгаа хийж байна.

37. “Хүүхдийн шударга байдлын төлөв” судалгааг 2012–2014 онд БНСУ-ын Транспрэнси интернэшнл байгууллагын боловсруулсан арга зүйгээр явуулсан байна. Хүүхдийн шударга байдлын түвшинг 1–5 оноогоор үнэлсэн бөгөөд уг үзүүлэлт 2013 онд 3.71 гарсан нь 2010 оныхоос 0.48 пункт, 2012 оныхоос 0.78 пунктээр тус тус өссөн байна. Судалгаагаар 12 настай хүүхдийн шударга байдлын түвшин 3.87 байсан нь бусад насны хүүхдээс өндөр байсан бол 11 настай хүүхэд хамгийн бага буюу 3.51 гарсан байв. Ёс зүй, ёс суртахууны дундаж үнэлгээ 2013 онд 3.80, зөв төлөвшлийн дундаж үнэлгээ нь 3.88,

хууль ягштал сахихын дундаж үнэлгээ 3.83 гарч, өмнөх оноос өссөн байхад авлигыг үл тэвчих байдлын дундаж үнэлгээ 3.35 гарч, өмнөх оныхоос 0.49 пунктээр буурсан байв. Судалгаагаар хүүхдийн хууль ягштал сахих чадварын дэд үзүүлэлтийн үнэлгээ 2013 онд өмнөх судалгааны дүнгээс нэмэгдсэн сайн тал буюу 2010 оноос 0.30, 2012 оноос 0.98 пунктээр нэмэгдсэн байна. Хүүхдийн шударга байдлын үнэлгээг хүйсийн хувьд авч үзвэл эрэгтэй хүүхдийн шударга байдлын үнэлгээ 3.69, охидынх 3.73 гарсан байгаа нь охид илүү шударга байв. Судалгаанд 7 аймаг болон Улаанбаатар хотын 3 дүүргийг хамруулсан бөгөөд судалгааны үр дүнгээр шударга байдлын үнэлгээ Улаанбаатар хотод 3.66, аймгийнх 3.75 гарсан нь орон нутгийн хүүхэд хотын хүүхдээс илүү шударга нь харагдаж байна. 2014 оны дээрх судалгаа хүүхдийн дундаж шударга байдлын үзүүлэлт дээшилснийг тэмдэглэж байна.

### **Хүүхдийн эрхийн сургалтын тогтолцоо**

38. Хүүхдийн эрх, Хүүхдийн Эрхийн тухай НҮБ-ын Конвенцийг сурталчлах, таниулан ойлгуулахад ХЭҮК өргөн оролцдог. Энэ комисс 2010 онд 23 сэдвээр 2996, 2011 онд 8 сэдвээр 2012, 2012 онд 12 сэдвээр 1424, 2013 онд 9 сэдвээр 1895 хүнд сургалт зохион байгуулжээ. Сургалтад оролцогч нь иргэд, олон нийт, төрийн болон нутгийн захиргааны байгууллагын албан хаагч, шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтан, албан хаагч, төрийн бус байгууллагын ажилтны төлөөлөл байв. Хүүхэд, эмэгтэйчүүд, оюутан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бэлгийн өөр чиг хандлагатай бүлгийн төлөөлөл ч хамрагдсан байдаг. Мөн ХЭҮК жилд хоёр удаа хэвлэн гаргадаг “Хүний эрх” онол, арга зүйн цуврал сэтгүүлээр дамжуулан зохих мэдээллийг олон нийтэд түгээдэг байна.

39. Албан бус боловсролын салбарт хүний эрхийн боловсролын сургалтын тогтолцоог бэхжүүлэх зорилгоор дунд сургуулийн багш, нийгмийн ажилтан 627 хүнийг тайлант хугацаанд сургалтад хамруулсан байна.

40. Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр “Хүний аюулгүй байдлын судалгааны төв” ТББ бусад талуудтай хамтран хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, түүний гаралтыг бууруулах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилготой онол практикийн бага хурал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, сурталчилгаа, цагдаа, хэв журмын ажилтан, мөрдөн байцаагч, нийгмийн ажилтны сургалт, уулзалт, ярилцлага зэрэг олон хэлбэрийн нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулжээ.

### **Хүүхдийн талаарх мэдээллийн тогтолцоо, ашиглалт**

41. ҮСХ нь макро эдийн засгийн, хүн ам, нийгмийн, үйлдвэрлэл, шинжлэх ухаан, технологийн, шүүхийн болон байгаль, хүрээлэн байгаа орчны гэсэн бүлгээр нийт 40 гаруй үзүүлэлтээр албан ёсны статистик, түүнчлэн мөнгө, зээл, санхүү, гааль, татвар, соёл, урлаг, боловсрол, хүн амын эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хүүхэд, хүнсний аюулгүй байдал гэсэн салбарын статистик мэдээллийг боловсруулан гаргадаг. ҮСХ –оос төрийн захиргааны болон олон улсын байгууллагуудтай хамтран, 2009 –2014 онд хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаар дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, нөхцөл байдлыг тодорхойлох 10 орчим судалгааг үндэсний хэмжээнд явуулсан байна. Үндэсний

статистикийн хорооноос гаргадаг хүүхдэд чиглэсэн судалгааны тоо, чанар дээшилсэн бөгөөд уг хорооны төсөв 2014 онд 2013 онтой харьцуулахад 440 сая төгрөгөөр нэмэгдэж, 9,3 тэрбум төгрөг болсон бол статистик судалгаанд 4,18 тэрбум төгрөг хуваарилсан байна. Улсын хэмжээний статистик судалгааны хувьд сэдэвчлэн тогтмол явагддаг “эрүүл мэндийн”, “нөхөн үржихүйн”, “хүүхэд хөгжил” гэсэн гурван төрлийн судалгааг нэгтгэн, анх удаа “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа”-г явуулж, түүнд 1,7 тэрбум төгрөг, өрхийн нийгэм, эдийн судалгаанд 1,9 тэрбум төгрөг зарцууллаа.

42. НҮБХС. Энэ байгууллагатай Засгийн Газар хамтран ажилласан олон жилийн арвин туршлагатай. НҮБХС нь 2012 –2016 онд үндэсний түвшинд хүүхдийн эрхийг бүрэн дүүрэн хангах нөхцөлийг бүрдүүлэх, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүүхэд, эмэгтэйчүүдэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаанд хөрөнгө төсөв хуваарилахад анхаарах, бодлого, хөтөлбөр, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, чадавхи бэхжүүлэхэд туслах бодлогыг баримтлан ажиллаж байна. Уг бодлогыг 1/ Хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн нийгмийн бодлого, хөрөнгө оруулалт, ухуулга нөлөөлөл, 2/ Бага насны хүүхдэд чиглэсэн цогц бөгөөд хүртээмжтэй үйл ажиллагаа, 3/ 6–18 насны хүүхдэд чиглэсэн цогц бөгөөд хүртээмжтэй үйл ажиллагаа гэсэн гурван хөтөлбөрөөр дамжуулан хэрэгжүүлж байна. Эдгээр хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2007 –2011 онд нийт 16 сая ам.долларын санхүүжилт үзүүлсэн бол 2012 –2016 онд 19 сая ам.долларын санхүүжилт хийхээр төлөвлөжээ.

43. Дэлхийн зөн ОУБ. Энэ байгууллага нь Монгол Улсад яаралтай тусламж, хөгжил, нөлөөллийн үйл ажиллагааг хүүхэд, гэр бүл, орон нутгийн иргэдэд үзүүлж байгаа христийн байгууллага юм. Тус байгууллага нь 1993 оноос өнөөг хүртэл нийт 16 аймгийг хамарсан хөгжлийн хөтөлбөрүүд хэрэгжүүлэв. Дэлхийн зөн Монгол байгууллагын 2013–2017 оны стратеги дараах 5 зорилтоос бүрдэж байна. Үүнд:

- Орон нутгийн иргэд, хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах
- Хүүхэд бүрт тэгш хүртээмжтэй, чанартай боловсролыг ээлтэй орчинд олгох
- Хүүхдийг хүчирхийлэл, аливаа эрсдэлээс хамгаалах
- Хүүхэд, өсвөр үеийнхнийг идэвхтэй, хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлэх
- Гэр бүл, орон нутгийн иргэдийн байгалийн гамшиг, эдийн засгийн эрсдэлийг даван туулах чадварыг дээшлүүлэх зэрэг болно.

44. Хүүхдийг Ивээх Сан. /ХИС/-ийн Монгол дахь хөтөлбөр нь 1994 оноос эхэлсэн бөгөөд 2009 оноос Японы Хүүхдийг Ивээх Сангийн удирдлагаар үйл ажиллагаа явуулж байна. ХИС –ийн Монгол дахь хөтөлбөр нь 2012 онд “Монгол Улсад 2012–2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө” боловсруулсан байна. Энэ стратегийн хүрээнд 1/ Хүүхэд хамгаалал, 2/ Хүүхдийн эрхийн засаглал, 3/ Боловсрол, 4/Эрүүл мэнд гэсэн үндсэн чиглэлийг тодорхойлсон байна. Үндсэн чиглэлийн хүрээнд Хүүхэд хамгаалал хөтөлбөр нь: Онцгой байдлын үед хүүхэд хамгааллын чиглэлээр хүний нөөцийг чадавхийг бэхжүүлэх төслийг хүүхэд хамгааллын байгууллагуудад; Нийгэмшүүлэх циркийн төслийг Нийслэлд; Эцэг эхийн халамж, хамгаалал дутагдсан хүүхдүүдэд хүүхэд төвөөр дамжуулан нийгмийн үйлчилгээ үзүүлэх төслийг Нийслэлд тус тус хэрэгжүүлсэн байна. Хүүхэд ээлтэй засаглалын хөтөлбөр нь Сайн засаглалд хүүхдийн оролцоог хангах

орон нутгийн загварыг туршиж, түүнчлэн сайн засаглалыг хөгжүүлэхийн тулд хүүхдүүд улсын төсөвт дүн шинжилгээ хийх төсөл хэрэгжүүлсэн байна. Боловсрол хөтөлбөр нь хүүхдэд ээлтэй цэцэрлэгийг загвар орон нутагт, алслагдсан хөдөө нутгийн малчин өрхийн хүүхдийн бага боловсролыг дэмжих төслийг сонгосон орон нутагт хэрэгжүүлсэн байна. Эрүүл мэндийн хөтөлбөрийн хүрээнд “Урьдчилан сэргийлж болох шалтгаанаар хүүхэд эндэх ёсгүй” сэдвээр сум дундын эмнэлэгт нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Түүнчлэн эрүүл мэнд, хоол тэжээл, ДОХ/ХДХВ болон гамшиг, аюулгүй байдлын асуудлыг хэсэгчлэн тусгасан байна. ХИС нь 2013 онд дээрх үйл ажиллагаанд 2,4 тэрбум төгрөгийн санхүүжилт хийж, 29183 хүүхдэд хүрч ажилласан байна.

45. Италийн төрийн бус АЙФО. Энэ байгууллагын санаачилгаар ДЭМБ, ЭМЯ-тай хамтран, Монгол Улс нийгэм хамт олонд тулгуурлан сэргээн засах хандлагыг 1991 оноос эхэлснээс хойш 20-иод жилийн дотор 21 аймаг 9 дүүрэгт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм хамт олонд түшиглэн сэргээн засах “Тэгш дүүрэн” хөтөлбөр хэрэгжиж, үндэсний хэмжээний хөтөлбөр болсон. Тус хөтөлбөрийн хүрээнд хийсэн судалгаагаар 2010 онд 0–15 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 11175, 2011 онд 11373, 2012 онд 11781, 2013 онд 11628 хүүхэд байна. Эдгээр хүүхдийн тоо 2010 оноос 2012 оныг хүртэл 5.4 хувиар өссөн бол 2012 оноос 2013 оныг хүртэл 1.2 хувиар буурсан байна. Тус хөтөлбөрийн хүрээнд жил бүр 21 аймаг, 9 дүүргээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоон мэдээлэл, судалгааг тусгай маягтын дагуу татан авч, СЗҮТ-д нэгтгэн мэдээллийн сан үүсгэн байршуулж байна.

46. Норвегийн тусламжийн байгууллага (НЛМ) Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг бэхжүүлэх төсөл нь Ховд, Говь-Алтай, Баян-Өлгий гэсэн баруун бүсийн аймгийг хамран, 2008–2012 онд хугацаанд амжилттай хэрэгжсэн үр дүн гарсан тул уг төслийн хоёр дахь үеийг үргэлжлүүлж байна. “Хүүхдийн эрх хөгжил” төсөл (ХЭХТ) 2009–2013 онд Ховд аймаг болон Улаанбаатар хотын гурван дүүрэгт амжилттай хэрэгжиж үр дүнгийн үнэлгээ хийж байна. Энэ байгууллага хүүхэд, гэр бүлд чиглэсэн баруун бүсийн аймгийн сургуулийн дотуур байрны нөхцөлийг сайжруулах төсөлд багагүй хөрөнгө оруулалт хийж, дэмжлэг үзүүлж, хамтран ажиллаж, олон нааштай үр дүнг гаргаад байна. Тус байгууллага нь хөдөөгийн алслагдсан сум, орон нутагт сургуулийн дотуур байрны орчныг сайжруулах, хүүхэдтэй ажилладаг багш, ажилчдын хандлагыг өөрчлөх, боловсон хүчнийг чадавхжуулах, хүүхдийн эрхийг орон нутагт сурталчлах зорилгоор 2009–2013 онд хэрэгжүүлсэн төслүүдээ 2014–2018 онд Ховд, Баян-Өлгий аймагт “Хүүхдийн эрх, хөгжил 2” нэртэй үргэлжлүүлэхэд гол түнш, хамтрагч байгууллага нь Хүүхдийн төлөө Үндэсний газар байна.

47. Монгол Улсад хүүхдийн амьдрах, сурч боловсрох орчинг сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын банк санхүүгийн байгууллагууд, Америк, Япон, Нидерланд, Австри зэрэг улсын Засгийн Газар дэмжлэг үзүүлж байна.

48. Монгол Улсын цэргийн бие бүрэлдэхүүн Афганистан, Сьери Леон, Өмнөд Судан зэрэг оронд НҮБ-ын мандат дор энхийг дэмжих ажиллагаанд 2009–2013 онд үүрэг гүйцэтгэж, нийт цэргийн 48 багийн 7207 алба хаагч ажиллагааны өмнөх бэлтгэл сургалтын явцад оролцов. Хүний эрхийн тухай түгээмэл Тунхаглал, Хүүхдийн Эрхийн

тухай Конвенцийн дагуу хүүхдийг цэрэг, зэвсэгт ажиллагаанд хамруулахгүй байх, цэрэг–хүүхэдтэй харьцах зэрэг сэдвээр хичээл сургууль, дадлагын ажил зохион байгуулснаар Хүүхдийн Эрхийн тухай Конвенцийн талаар тодорхой мэдлэгтэй болсны үндсэн дээр тухайн газар оронд үүрэг гүйцэтгэв. Үүний үндсэн дээр Конвенцийн хэрэгжилтийг биелүүлэх, хүүхэдтэй зөв боловсон харьцах, хүүхдийн эрхийг хамгаалах талаар ямар нэгэн зөрчил гаргаагүй байна.

49. Монгол Улсад хууль зүйн дагуу бүртгэлтэй хүүхэд, гэр бүлд чиглэсэн үйл ажиллагаа эрхэлдэг, сүүлийн хориод жилийн турш тогтвортой ажиллаж байгаа байгууллагууд тайланд хугацаанд үндсэн 4 сүлжээ зохион байгуулалтад орж нэгджээ. (Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээ, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний сүлжээ, Хүүхдийн оролцооны байгууллагуудын сүлжээ, Экпат–Монгол сүлжээ.)

50. Ийнхүү мэргэшиж төрөлжсөн эдгээр байгууллагуудтай хамтран ажиллаж төрийн байгууллагаас үзүүлэх боломжгүй зарим яаралтай шинэ төрлийн үйлчилгээг шаардлагатай талд хүргэх нь хөрөнгө, нөөцийг хэмнэх төдийгүй, хүүхдийн байдлыг сайжруулахад цаг алдахгүй, оновчтой, шуурхай байдаг давуу талтай гэж үзээд ХТҮГ дээрх сүлжээдээр дамжуулан иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах чиглэл баримталж байна. Тухайлбал, 2011 онд 220 гаруй сая төгрөгийн төсөвтэй үйлчилгээг тэдний тусламжтайгаар хэрэгжүүлэхээр гэрээлээд ажиллаж байна. 2013–2014 онд бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдэд хамтарсан багаар үйлчилгээ үзүүлэх, шүүхийн журмаар гэр бүл цуцлалтад хүүхдийн асран хамгаалалд шинжээчийн дүгнэлт гаргах, хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй хүүхдийг нийгэмшүүлэх, хүүхэд хамгааллын эрх зүйн орчныг сайжруулах нөлөөллийн багаар ажиллах, хүүхдийн тусламжийн утасны зөвлөгч–операторуудыг ажлын байранд нь чадваржуулахад зөвлөн туслах зэрэг үйл ажиллагааг иргэний нийгмийн байгууллагуудын зохих дэмжлэгтэйгээр хамтран хэрэгжүүлж байна.

### **Хоёр. Хүүхдийн тодорхойлолт**

51. Энэ талаар Монгол Улсын өмнөх тайлан илтгэлийн 61–66 дугаарт бий.

52. Хүүхдийг сургуульд 6 наснаас эхлэн хамруулж, 12 жилийн хугацаанд бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх бодлогын дагуу суралцахад хүүхэд 14–15 насандаа Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд орж, 16–17 насандаа мэргэжил эзэмших боломжтой байна. Энэ нь 18 нас хүрээгүй байхдаа ажил хөдөлмөрийн талбарт гарах болж байна. Иймд хууль эрх зүйн орчинд хүүхдийн дээд эрхийг хамгаалах бас нэгэн шинэчлэл шаардаж байна.

53. Иргэний хуульд тодорхойлсон эрх зүйн бүрэн ба бүрэн бус чадамж, эрх зүйн зарим чадамж, эрх зүйн чадамжгүй гэсэн тодорхойлолт шүүхийн практик хүчин төгөлдөр үйлчилж байдаг. 14–18 насны /насанд хүрээгүй/ иргэнтэй хэлцэл хийгч этгээд хэлцлийг дэмжсэн зөвшөөрлийг хууль ёсны төлөөлөгчөөс хүсвэл тэрээр зөвшөөрөх эсэхээ 14 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ. Хуульд заасан хугацаанд хариу өгөөгүй бол зөвшөөрөл олгохоос татгалзсан гэж үзнэ. Мөн 18 насанд хүрээгүй хүүхдийн эцэг, эх, хууль ёсны төлөөлөгч /асран хамгаалагч, харгалзан дэмжигч/–өөс бичгээр зөвшөөрөл



авч, нарийн төвөгтэй оношлогоо, мэс засал хийх, түүнийг анагаах ухааны судалгаа, туршилтад оролцуулна.

### **Гурав. Хүүхэд, хүүхдийн эрхийн үндсэн зарчмууд**

#### **Үл ялгаварлах**

54. Хүүхдийн Эрхийн тухай Конвенцийн 2 дугаар зүйлд хүүхэд, түүний эцэг, эх буюу хууль ёсны асран хамгаалагчийг яс үндэс, гарал угсаа, арьс өнгө, хүйс, хэл, шашин, улс төрийн болон бусад үзэл бодол, нийгмийн гарал, эд хөрөнгө, эрүүл мэнд, биеийн төрсөн, олдмол байдал болон бусад байдлаас шалтгаалан аливаа хэлбэрээр алагчлахгүй байх, Конвенцийн бүх эрхийг хүүхэд бүрийн хувьд хүндэтгэн хүргэхээр заасан бөгөөд энэ үзэл санааг Монгол Улсын Үндсэн хуульд баталгаажуулсан байдаг.

55. Төрсөн болон олдмол байдал, бусад байдлаас шалтгаалан аливаа хэлбэрээр алагчлахгүй байх асуудал хуулиар баталгаажсан ч амьдрал дээр хүүхэд нийгмийн байдал, гарал үүсэл, газар зүйн байрлал, сурлагын байдал төдийгүй хөгжлийн бэрхшээл зэргээс шалтгаалан тэгш бус байх, ялгаварлагдах тохиолдол байна.

56. Нийгэмд амьдралын ялгаатай хэв маяг үүсч байгаагаас улбаалан хүүхэд, өсвөр үеийнхний дунд амьдралын түвшин, гарал үүсэл, боловсрол, гадаад байдал, хөгжлийн бэрхшээл зэргээр нь ялгаварлах харилцаа хандлага төлөвшихөөс урьдчилан сэргийлэхэд анхааралтай хандаж байна.

#### **Хүүхдийн дээд ашиг сонирхлыг дээдлэх**

57. Хүүхдийн дээд ашиг сонирхол гэдэг нь хүүхэд хэнтэйгээ амьдрах, хэнээс дэмжлэг туслалцаа авах, эцэг эхтэйгээ харилцах зэргийн үл хязгаарлахтай холбоотой эрх зүйн ойлголт юм. ХЭК-ийн 3 дугаар зүйлд заасан хүүхдийн дээд эрх ашгийг хамгаалах тухай зүйл, заалтыг Гэр бүлийн тухай зэрэг шинээр боловсруулж байгаа болон шинэчлэн найруулж буй хуулийн төсөлд тусгаж байна.

58. Хүний эрх, ялангуяа хүүхдийн эрхэд ээлтэй байх зарчимд суурилсан Шүүхийн шинэтгэлийн тухай багц хуулиуд батлагдан хэрэгжиж эхэллээ. Сүүлийн долоон жилд 52 иргэн эцэг, эх байх эрхээ шүүхээр хасуулсан байна. Гэр бүлийн тухай хуульд зааснаар ихэнх нөхцөлд хүүхэдтэйгээ ёс бус харьцсан тохиолдолд ийм шийдвэр гаргадаг байна. Гэхдээ эцэг байх эрхийг нь хасаж, хүүхдийг асрамжид авах нь хүүхдийг хамгаалах, төлөвшүүлэх шилдэг арга биш, хүүхдээ харж хандаж чадахгүй байгаа ухамсаргүй эцэг эхийн эрхийг хасах, хязгаарлахаас илүү нийгэмшүүлэх ёстой гэдгийг мэргэжилтнүүд зөвлөж байгаа юм. Нэгэнт эцэг эх байх эрхээ хасуулсан бол эргээд хүүхдээ өөр дээрээ авах нь хүндрэлтэй байдаг. Нөгөө талаас хүүхэд гэр бүлээсээ хол хөндий өсөх шалтгаан болно. Тиймээс хүүхэд гэр бүлтэйгээ ойр байх ёстой гэсэн зарчмын дагуу хүүхэд, гэр бүлийн хөгжлийг дэмжих бодлого барьж байна. Эрүүгийн хуульд зааснаар хууль зөрчин, эрүүгийн хариуцлага хүлээж байгаа насанд хүрээгүй этгээдэд оногдуулах ялын бодлого, шийтгэлийг хүүхдэд ээлтэй байх зарчмыг баримтлан хэрэгжүүлж байна.


**Амьд явах эрхийг хамгаалах**

59. Хүүхэд амьд явах жам ёсны эрхтэй бөгөөд Засгийн Газар хүүхэд бүрийг эсэн мэнд амьдрах, хөгжих бололцоогоор дээд зэргээр хангах үүрэгтэй.

60. 1990 онд 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэл насны хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөд 87.5, нялхсын эндэгдлийн түвшин 63.4 байсан бол 2007 онд энэ үзүүлэлт 22.1 ба 17.8 болж, Мянганы хөгжлийн зорилтоо хангасан тул 2008 онд УИХ –ын 25 дугаар тогтоолоор Засгийн Газраас хүрсэн амжилтаа бататгахын тулд 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэл насны хүүхдийн эндэгдлийг 21.0, нялхсын эндэгдлийг 15.0–д хүргэх шинэ зорилтуудыг дэвшүүлсэн юм. Хүн ам зүйн 2009 –2013 оны статистик мэдээллээс харахад жилд дундажаар 19 хүртэл насны 2000 орчим хүүхэд нас барж байгаа ба нийт хүн амын нас баралтын 10 гаруй хувийг эзэлж байна.

61. 2013 оны байдлаар нялхсын болон тав хүртэл насны хүүхдийн эндэгдэл 1990 оноос хойшхи 20 жилийн хугацаанд эрчимтэй буурч байна.

*Хүснэгт 6. Нялхсын болон тав хүртэл насны хүүхдийн эндэгдэл 1990–2013 он.ЭМЯ*



*Улаан – 5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл,  
Цэнхэр – нялхсын эндэгдэл*

Нийт бүртгэгдсэн тав хүртэл насны хүүхдийн нийт нас баралтын 20 хувь нь эмнэлгээс бусад газарт тохиолдсон нь нас барж буй 5 хүүхэд тутмын нэг нь эмнэлгийн тусламж авч чадаагүй байгааг харуулж байна. Эдгээр нь гэнэтийн осол гэмтэл болон төвөөс алслагдсан газар зүйн байрлалаас үүдэлтэй юм.

62. Улсын хэмжээнд 2009 онд зам тээврийн осолд орсон 552 хүүхдийн 36, 2010 онд осолд орсон 617 хүүхдийн 28, 2011 онд осолд орсон 962 хүүхдийн 40, 2012 онд осолд орсон 959 хүүхдийн 43, 2013 онд осолд орсон 1218 хүүхдийн 37 нь амиа алдсан байна. 2009 –2013 онд нийт 4074 хүүхэд зам, тээврийн ослын хохирогч болсны 35,0 хувь нь 0–6 насны, 48,0 хувь нь 7–14 насны, 16,5 хувь нь 15 –17 насны хүүхэд байв. Зам тээврийн осолд өртсөн хүүхдийн 77,6 хувь явган зорчихдоо, 21,1 хувь нь автомашинд, 1,1 хувь нь унадаг дугуйгаар явж байхдаа хохирчээ. Эдгээр хүүхдийн 57,6 хувь хөвгүүд байжээ.

Улсын хэмжээнд тохиолдсон аюулт үзэгдэл, үйлдвэрлэл, техникийн ослын улмаас 2009 онд 41 хүүхэд, 2010 онд 68 хүүхэд, 2011 онд 41 хүүхэд, 2012 онд 56, 2013 онд 44 хүүхэд амь насаа алдсан нь харамсалтай. Өнгөрсөн хугацаанд золгүй тохиолдлоор нас барсан 259 хүүхдийн нас баралтын шалтгааныг задалж үзвэл объектын гал түймэрт 107, нуурын усанд 114, аянгад 7, хүчтэй салхи шуурганд 5, үерт 18, бичил уурхайн осолд 2, хурдан морины уралдааны осол гэмтлээс 6 хүүхэд эндсэн байв.

63. Хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах олон нийтийн санаачилгыг Засгийн Газар 2011–2012 онд дэмжиж ажилласан байна. Энэ хүрээнд хүүхдийг болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх олон нийтийн санаачилгыг өрнүүлэх удирдамжид үйл ажиллагааны стратеги, оролцогч, дэмжигч талуудын хамтран ажиллах арга зүйг тодорхойлсон байна. Санаачилгын хүрээнд нийгэм, ахуйн ослоос сэргийлэх, зам, тээврийн ослоос сэргийлэх, дарамт хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхдийг хүнд, тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрөөс сэргийлэх, гамшгийн аюулаас сэргийлэх гэсэн үндсэн чиглэлээр Ажлын хэсэг хороо байгуулагдан, эцэг эх, хүүхэд, олон нийтэд нөлөөлөх, хамтран ажиллахыг эрмэлзэн, хэрэгжилтийн тайланг жил бүр гаргаж, Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөлд танилцуулсан байна.

#### **Хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх**

64. Хүүхдийг өөртэй нь холбоотой асуудлыг шүүх буюу захиргааны журмаар хэлэлцэхэд шууд, эсвэл хуульд заасны дагуу төлөөлөгч, зохих байгууллагаар дамжуулан үг хэлэх бололцоог хүүхдэд олгосон.

65. Эрхэлсэн сайдын тушаалаар баталсан “Хүүхдийн оролцоог дэмжих стратеги”-д хүүхдийг сонсох, механизмыг хууль, тогтоомж, дүрэм, журамд тусгах, хүүхдэд үзэл бодлоо болон өөрийгөө илэрхийлэн ойлгуулах чадварыг хөгжүүлэх, төрийн болон нутгийн захиргааны байгууллагууд хүүхэдтэй холбоотой асуудал хэлэлцэхдээ хүүхдийн санал бодлыг сонсох, шийдвэртээ тусгах, хүүхдийн санал бодлыг хэрхэн тусгасан талаар эргэн мэдээлэх, мөн хүүхдийн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэж, хариу өгөх тогтолцоог хөгжүүлэх үйл ажиллагааг тусгасан байна.

66. Стратегийн дагуу аймаг, дүүрэг, нийслэлд хүүхдийн чуулган жил бүр болж, хүүхдүүд, хүүхдийн төлөөлөл хамтран ярилцах, тулгамдсан асуудал, дуу хоолой, санал хүсэлтээ шийдвэр гаргагч нарт сонсгодог хэлбэр нэгэнт тогтоод байна. Тайлангийн хугацаанд орон нутаг, үндэсний хэмжээнд жил бүр хүүхдийн чуулганыг зохион байгуулж, мөн хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөр эрхэлдэг, хурдан морь унадаг хүүхдийн асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулан, хэлэлцэж тэнд хүүхдүүд үзэл бодлоо илэрхийлэн, өөрсдийгөө сонсгох, шийдвэр гаргах түвшинд дуу хоолойгоо хүргэх, түүнийг нь шийдвэрлэх хүсэл зориг гаргах зэрэг үйл ажиллагааг явуулдаг хэлбэр орон нутагт түгээмэл байна.

#### **Дөрөв. Иргэний эрх, эрх чөлөө**

##### **Нэр, харьяалал, бүртгэл**

67. Гэр бүлийн тухай хуульд эцэг, эх тохиролцсоны үндсэн дээр хүүхэддээ нэр, овог өгнө гэж заасан ба олдсон хүүхдэд сум, дүүргийн Засаг дарга, эсвэл иргэний бүртгэлийн

байгууллагын ажилтан овог нэр өгч болно гэжээ. Гэрлэлтээ бүртгүүлээгүй эхээс төрсөн, хүүхдийн эцгийг тогтоосон эрх бүхий байгууллагын шийдвэргүй бол хүүхэд эхийн нэрээр овоглоно. Үрчлэгдсэн хүүхэд үрчлэгчийн нэрээр овог авна.

68. Монгол Улсад хүүхэд төрснөөс хойш төв суурин газарт 15 хоног, сум багт 30 хоногийн дотор эцэг, эх, хэрэв эцэг эх хоёулаа бүртгүүлэх боломжгүй бол тэдний төрөл садны хүн, хүүхэд байгаа эмнэлгийн байгууллагын эрх бүхий ажилтан иргэний гэр бүлийн бүртгэлд үнэ төлбөргүй бүртгүүлэх үүргийг хүлээж байдаг. Хүүхдийг бүртгэхэд хүүхэд төрсөн тухай эмнэлгийн магадлагаа, эрүүл мэндийн дэвтэр, хэрэв эмнэлгийн магадлагаа авах боломжгүй нөхцөлд хөндлөнгийн тодорхойлолт, эцэг эхийн үнэмлэх, эцэг эхийн гэрлэлтийн гэрчилгээ шаардлагатай. Хаягдсан хүүхдэд иргэний бичиг баримт олгохдоо цагдаагийн байгууллагын тодорхойлолт, эмнэлгийн байгууллагын нас, хүйсний тодорхойлолтыг үндэслэж бүртгэнэ. Хүүхдийг иргэний бүртгэлд бүртгэхээс өмнө нас барсан бол эмнэлгийн магадлагааг үндэслэнэ. Хүүхэд бүртгэснийг баталгаажуулж, төрсний гэрчилгээ олгох бөгөөд түүнд хүүхдийн овог, эцэг эсвэл эхийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, хүйс, мэндэлсэн газар, төрсний бүртгэл үйлдсэн газрын нэр, гэрчилгээний болон регистрийн дугаар, төрсний гэрчилгээ олгосон он, сар, өдөр зэргийг тусгасан байна.

69. Монгол Улсад 2009 онд 69301 хүүхэд, 2010 онд 62853 хүүхэд, 2011 онд 72667 хүүхэд, 2012 онд 73205 хүүхэд, 2013 онд 79231 хүүхэд шинээр төрснийг УБЕГ бүртгэсэн байна. Судалгаагаар 0–11 сартай хүүхдийн төрсний бүртгэлд хамрагдалт 95 хувь байсан бол 12 –оос дээш сартай хүүхдийн төрсний бүртгэлд 100 хувь байв. Энэ нь Монгол Улсад хүүхдийг төрсний бүртгэлд хамруулах замаар нийгмийн суурь үйлчилгээнд хамруулах боломж бүрдсэн дахин нотолж байна.

70. Гадаадад оршин суугаа Монгол Улсын харьяат иргэнээс төрсөн хүүхдийг төрүүлсэн эцэг, эхийн хүсэлтийг үндэслэн хилийн чанад дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар, консулд 30 хоногийн дотор бүртгэж байна. Эцэг, эхийн аль нэг нь Монгол Улсын харьяат, нөгөө нь гадаад улсын харьяат, харьяалалгүй хүн бол эцэг, эхийн хүсэлт, харилцан тохиролцсон байдлыг үндэслэн, тухайн журмын дагуу бүртгэнэ. Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэн, харьяалалгүй хүнээс төрсөн хүүхдийг журмын дагуу бүртгэнэ. 2013 оны байдлаар эцэг эхийн аль нэг нь гадаад улсын иргэн бүхий гэр бүлээс төрсөн, Монгол Улсын төрсний гэрчилгээ авсан 1111 хүүхэд байна.

### **Мэдээлэл олж авах эрх, эрх чөлөө**

71. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх чөлөөний тухай хуулийг 2011 онд баталж, хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарлахыг хуулиар хориглосон. Хүүхэд чөлөөтэй бодож сэтгэх, мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Монгол Улсад үндэсний аюулгүй байдлын эсрэг үйл ажиллагаа явуулах, терроризм болон бусад гэмт хэрэг, садар самуун, хүчирхийллийг сурталчлах, түүнчлэн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон хүүхэд өөрөө хүсээгүй бол хүүхдийг сурталчилгаанд ашиглахыг Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулиар хориглосон.

72. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл хүртэх боломжийг бүрдүүлэхэд Монгол Улсын Засгийн Газар анхааран ажиллаж байна. Үүний нэг нь Олон Улсын

цахилгаан холбооны байгууллагын дэмжлэгтэйгээр DAISY консерциум, Хараагүйчүүдийн үндэсний хороо бусад төрийн захиргааны байгууллага сурах бичгийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ашиглах боломжтой түгээмэл загвараар боловсруулах, Хүртээмжтэй тоон мэдээллийн систем /DAISY/ стандартыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж байна. Мөн 102, 103, 105 зэрэг шуурхай тусламжийн утсанд муу сонсдог болон сонсголгүй хүмүүст цахилгаан холбооны хэрэгсэл /Telecommunication device for deaf and hard of hearing/–ийг технологийг нэвтрүүллээ.

73. Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд олон нийтийн радио, телевизийн мэдээлэл, нэвтрүүлгийг дохионы орчуулгатай, урсгал мэдээлэлтэй, мөн бичгэн мэдээллийг хараагүй хүмүүст боломжтой хэлбэрээр хүргэхээр заасан байдаг. Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз дохионы орчуулга, урсгал мэдээлэлтэй, харин бусад телевизийн хувьд урсгал мэдээллийг гаргах боллоо. Түүнчлэн үндэсний цөөнхөөс, хүүхдэд зориулсан мэдээллийн нэвтрүүлэг явуулдаг боллоо. Интернэтийг харааны бэрхшээлтэй хүмүүс ашиглах боломжоор хангах ажлыг эхлүүлэн, үе шаттай бэлтгэл ажлыг хийж байна.

74. Хүмүүс олон нийтийн цахим сүлжээг ашиглах явцдаа гүтгэгдэх, доромжлогдох, садар самуунд уруу татагдах, сэтгэл зүйн дарамтад орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Сайтууд дахь сэтгэгдлийн харилцааг зохицуулах” журмыг Харилцаа холбооны зохицуулах хорооноос гаргаж, үүний дагуу хэрэглэгчийн интернэт протокол хаягийг ил тавих, зүй бус 200 гаруй үг хэллэгийг хэрэглэхийг хязгаарлах зохицуулалтыг хийх боллоо.

75. Интернетийн хэрэглээ өсч байгааг дагаж, сөрөг нөлөө нь нэмэгдэж байна. Олон нийтийн сүлжээний мэдээллээс хүүхдэд тохиромжгүйг нь ялгаж шүүх, хүүхдэд зориулсан мэдээллийг хянах боломж сул тул хүүхэд мэдээллийн сөрөг нөлөөнд автах тохиолдол гарч байна. Иймд интернетийн зохистой хэрэглээг дэмжих арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байна.

### **Хүүхдийг хүнлэг бус, бие махбодын харгис шийтгэлээс хамгаалах**

76. Монгол Улсад хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг, бүх орчинд Боловсролын тухай хуулиас бусад хуулиар хориглож чадаагүй байна. ҮСХ–оос 2010–2014 онд хийсэн “Хүүхэд хөгжил” 3 ба 4 дүгээр судалгаа болон Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаанаас харахад 2–14 насны хүүхдийн 45–47% нь гэр бүлийн хэн нэг гишүүний зүгээс үзүүлэх биемахбодийн шийтгэл амсдаг дүн гарч байна. Хүчирхийлэлд өртсөн хүүхэд дан ганц бие махбодийн хувьд хохироод зогсохгүй, сэтгэл зүйн хувьд шарх авч, улмаар тэдний хөгжил, бие махбод, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг.

77. ЦЕГ 2009 онд 261, 2010 онд 290, 2011 онд 418, 2012 онд 382, 2013 онд 464 хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд хамруулсан байна. Энэ үзүүлэлт нь нэг талаас хүүхдийн эсрэг хүчирхийлэл нэмэгдэж байгаа, нөгөө талаас үйлчилгээний хүртээмж нэмэгдсэнийг харуулж байна. Гэхдээ хүчирхийлэлд өртсөн хүүхдийн хэдэн хувьд дээрх үйлчилгээ хүрч чадаж байна вэ гэдэг анхаарал татсан асуудал юм.

78. Сургууль, цэцэрлэг, асрамж, халамжийн байгууллагын орчинд хүүхэд хүчирхийлэлд өртөх явдал буурахгүй байна. 2011 онд 275 хүүхэд, 2012 онд 291 хүүхэд,

2013 онд 279 хүүхэд биеэ махбодын аль нэг хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн гэж цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн байна. Сургууль, цэцэрлэгийн орчинд хүүхэд хүчирхийлэлд өртөх шалтгаан нөхцөл маш олон талтай хэвээр байна. Иймд сургууль, цэцэрлэгийн орчин нөхцөл, нэг анги, нэг багшид ноогдох хүүхдийн тоо, багшийг бэлтгэсэн, сургасан байдал зэрэг олон хүчин зүйлийн нөлөөллийг судлах шаардлага гарч байна. Сургууль, цэцэрлэгийн орчинд гарч байгаа ихэнх хүчирхийлэлд багш нь хүүхдийг ямар нэг хэлбэрээр хүчирхийлсэн байдлаар илэрч, багш шийтгэл авсаар байна. Иймд багш нарыг хүчирхийлэлгүй заах арга зүйд сургах, урьдчилан сэргийлэх, зайлшгүй нөхцөлд хамгаалах тогтолцоог хөгжүүлэх, багшийн ажиллах орчинг сайжруулах шаардлагатайг нотолж байна.

79. УИХ 2004 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Засгийн Газар 2007 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийг батлан гаргасан. ХЗЯ, ЭМЯ, НХХЯ зэрэг төрийн төв байгууллага дээрх хууль, хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зарим заавар, журмыг боловсруулж, баталсан байна.

80. Хүчирхийлэлд өртөгсдөд нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх төв байгуулах төслийн хүрээнд урьдчилсан тооцоог хийх замаар Говь –Алтай аймгийн Нэгдсэн эмнэлэгт, Завхан аймгийн Цагдаагийн газарт түшиглэсэн загвар төвийг НҮБ–ын Хүн амын сантай хамтран байгууллаа.

### **Тав. Гэр бүлийн орчин ба асран хамгаалал**

#### **Гэр бүлд чиглэсэн үйлчилгээ**

81. Засгийн Газар аймаг, нийслэлд хүүхэд, гэр бүлд үйлчилгээ үзүүлэх зорилготой Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс, газрыг байгууллаа. Нийслэлийн дүүрэгт хүн амын төвлөрөл, үйлчилгээний хэрэгцээг харгалзан, 9 дүүрэгт Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төв шинээр байгуулав.

82. Монгол Улсын бүх шатанд нийгмийн халамж, үйлчилгээг хүмүүст хүргэх чиглэлээр 1500 гаруй нийгмийн ажилтан ажиллаж байгаа Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийгмийн ажилтан нь “хүн ам, гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр батлагдсан үндэсний хөтөлбөр, арга хэмжээг орон нутагтаа хэрэгжүүлэх ажлыг эрүүл мэндийн, боловсролын болон бусад нийгмийн ажилтантай хамтран зохион байгуулах” чиг үүрэгтэй гэж заасан байна. Энэ хүрээнд нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах хоёр удаагийн шаталсан сургалтыг 2013–2014 онд зохион байгуулж, эхний удаагийн сургалтад 1217, хоёр дахь удаагийн сургалтад 1311 хүнийг хамруулсан байна.

83. Гэр бүлийн зөвлөлгөө өгөх төвд тавигдах нийтлэг шаардлага “MNS 6417” стандартыг 2013 онд баталснаар Монгол Улсын хэмжээнд гэр бүлд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлдэг төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагын ажилтны үүрэг, үйл ажиллагааны чиглэл, агуулга, хэм хэмжээг тогтоож өглөө. Гэр бүлийг дэмжих үйлчилгээнд юуны өмнө эмзэг бүлгийн, ажилгүй, зан төлөвийн өөрчлөлттэй, амьдрах чадвар сул, архины, дон, муу зуршил бүхий иргэн, тэдний гэр бүлийн гишүүдтэй ажиллах, нөлөөлөх үйлчилгээ, төдийгүй тодорхой мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийг бэлтгэх, чадваржуулах, хүний нөөцийг бэлтгэх зэрэг асуудал тулгарч байна.

84. Засгийн Газрын тухай хуульд төрийн зарим чиг үүргийг ТББ–аар гүйцэтгүүлэх, иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах талаар тодорхой заасан байдаг. Түүнчлэн гэр бүлийн амьдралд сөрөг асуудал үүсэхээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих, нийгмийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх гэр бүлийн боловсрол олгох сургалт, үйлчилгээний хэрэгцээ түгээмэл шаардлагатай байна.

85. 2009 онд батлагдсан Хүний хөгжлийн сангийн тухай хуулийн дагуу иргэн бүрт жил бүр хишиг хувь ноогдуулж, дунджаар 1,5 сая төгрөгийг олгосон байна. 2013 оноос дээрх хуулийг өөрчилж, 18 хүртэл насны хүүхэд бүрд сар бүр 20 мянган төгрөгийг “Хүүхдийн мөнгө” нэрээр олгож байна. Хүний хөгжил сангаас хүүхдэд мөнгө олгосон үйлчилгээ нь 2013 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 960279 хүүхдэд 228,9 тэрбум төгрөг болсон бөгөөд эдгээр хүүхдийн 60 гаруй хувь нь мөнгөө банкинд байршуулж, хуримтлал үүсгэсэн байна. Хүүхдийн мөнгө олгох журмын 3.4, 3.5 дугаар зүйлийн дагуу асрамж, халамжийн төв, хорих ангид ял эдэлж буй хүүхэд, хараа хяналтгүй амьдарч байгаа асрамжийн 984, хараа хяналтгүй 245, эрх чөлөөг хасуулсан 4, нийт 1223 хүүхдийн 221,9 сая төгрөгийн мөнгөн хуримтлалыг хүүхдийн нэрийн дансанд байршуулсан байна.

#### **Эмзэг бүлгийн гэр бүл, хүүхдэд зориулсан үйлчилгээ**

86. 2013 онд Өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах аргачлалын дагуу ядуу, дэмжлэг авах шаардлагатай 15000 өрхийн 65 мянган иргэн оролцож, хөгжлийн төлөвлөгөөгөө боловсруулжээ. Өрхийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулахад орон нутагт Нийгмийн даатгалын хэлтэс, Боловсролын хэлтэс, Эрүүл мэндийн хэлтэс зэрэг байгууллага хамтран ажиллаж, өрхийн гишүүдийн хөгжилд чухал нөлөөтэй 20 үзүүлэлтээр үнэлгээ хийж, нэн шаардлагатай нийгмийн суурь үйлчилгээг уялдуулан зуучлах, сургалтад хамруулах, чадваржуулах ажлыг хэрэгжүүлжээ. Өрхийн сургалт нь гэр бүлийн гишүүдэд эерэг зан үйл төлөвшүүлэх, өөртөө санаа тавих, хариуцлага хүлээх чадвар, эрмэлзэлийг дэмжихэд чиглэж байна.

87. 2013 онд өрхийн амьжиргаа тодорхойлох судалгааг орон даяар зохион байгуулж, 712,044 өрхийн 2,360, мянга гаруй иргэний мэдээллийг агуулсан салбар дундын цахим мэдээллийн санг үүсгээд байна. Энэ санг ашиглан, хүнсний эрхийн бичиг олгох үйлчилгээг эхлүүлсэн бөгөөд уг үйлчилгээнд хүнсний дэмжлэг зайлшгүй шаардлагатай, хамгийн бага хэрэглээтэй 15131 өрхийн, 87217 иргэн хамрагдаж байна. Эдгээрийн 47523 нь насанд хүрсэн хүн, 39694 нь 18 хүртэл насны хүүхэд байна. Хүнсний эрхийн бичгийг насанд хүрсэн нэг иргэнд сар бүр 10,000 төг, хүүхдэд сар бүр 5,000 төгрөг олгохоор журамлан хэрэгжүүлж эхэллээ. Эрхийн бичгийг хөдөөгийн сумдад бэлэн хэлбэрээр, харин нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн төвд цахим картаар олгож байна. Мөн ЭМЯ–тай хамтран ядуу өрхийн эрүүл мэндийн картын үйлчилгээнд 16883 өрхийн, 119187 гишүүдийг хамруулсан байна.

#### **Асрамжийн үйлчилгээ**

88. ХАХНХ–ын Сайд 2013 онд “Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын мөрдөх үлгэрчилсэн дүрэм”–ийг шинэчлэн баталсан байна. Энэ дүрэм ёсоор хүүхдийн асрамж, халамжийн төв нь асран халамжлагч нь нас барсны улмаас асран хамгаалагч,

хүмүүжүүлэгчийн үүргийг хүлээх төрөл, төрөгсөд, хамаатан садангүй, эсвэл зайлшгүй асрамж, хамгааллын үйлчилгээ авах шаардлагатай нь орон нутгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлөөр тогтоогдсон, 18 хүртэл насны хүүхдэд байнгын болон түр хугацааны үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллага байна гэжээ. Энэ байгууллага нь хүүхдийн асрамж, халамж, хамгааллын үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага “MNS 5852:2008” стандартыг хангаж ажиллана.

89. ХТҮГ 2013 оноос эхлэн энэ төрлийн үйлчилгээ үзүүлэгчдэд зөвшөөрөл олгож эхэлсэн бөгөөд үүнтэй холбогдуулан төвлөрсөн үйлчилгээний хэлбэрээс хувилбарт үйлчилгээний хэлбэрт шилжих бэлтгэлийг хангалаа. Улсын хэмжээнд хүүхдэд чиглэсэн асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлдэг 20 шахам байгууллагын 39 нэгж ажиллаж байна. Тэдний 36 нь Улаанбаатар хотод байрлаж байна. Асрамж, халамжийн төвд амьдарч байгаа хүүхдийн 24 хувь нь гэр бүлтэй хүүхэд байна. Энэ үйлчилгээнд хамрагдаж байгаа 1260 хүүхдийн шилжилт хөдөлгөөн, гэр бүлдээ эргэн нэгтгэх бэлтгэл, үр дүн зэргийг нэгтгэн хянах бүртгэлийн онлайн системийг ХТҮГ ажиллуулж байна.

90. Сүүлийн хорь гаруй жил ЭМЯ-ны харьяанд байсан сувиллын чиг үүргийг зөвхөн нярай хүүхдэд сувилгаа, асаргаа үзүүлэхээр өөрчилж байгаа тул тус төвд асран хамгаалагчгүйн улмаас өсөж торниж байгаа 20 гаруй хүүхдийг асрах үйлчилгээнд шилжүүлэх асуудал тулгарч байна.

### Үрчлэл

91. Монгол Улс “Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай” Гаагийн Конвенцид 1998 онд нэгдэн орсноос хойш гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх асуудлыг Гэр бүлийн тухай хууль болон Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаалаар 2001 онд баталсан “Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журам”-аар тус тус зохицуулж байна. Хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх үйл ажиллагааг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар хамтран гүйцэтгэдэг бөгөөд гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэх асуудлаар гадаад орнуудын “Хүүхэд үрчлэл”-ийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон тэдгээрийн итгэмжлэгдсэн байгууллагатай хамтран ажилладаг. Хүүхэд үрчлэн авах хүсэлтэй гадаадын иргэн хууль, тогтоомжид заасан материалыг бүрдүүлж, өөрийн орны харьяалах байгууллагаар дамжуулан, ХАХНХЯ-нд хүсэлт, материал ирүүлснийг тус яамны дэргэдэх “Үрчлэлийн зөвлөл”-өөр хэлэлцүүлж хэрвээ хууль журамд заасан шаардлагад нийцэж, хүүхэд үрчлэн авах боломжтой гэж үзсэн нөхцөлд үрчлэгдэх хүүхдийг сонгож, үрчлэх хүсэлт гаргасан гадаадын иргэнд санал болгон, тэдний зүгээс зөвшөөрсөн тохиолдолд холбогдох дүгнэлтийг ИХШХЕГ –т хүргүүлдэг. Дээрх дүгнэлтийг үндэслэн хүүхэд үрчлүүлэх тухай эцсийн шийдвэрийг тус газрын даргын тушаалаар гаргадаг бөгөөд үрчлэгдсэн хүүхдийн эрх хамгаалалд хууль, журамд заасны дагуу ИХШХЕГ хяналт тавих үүрэгтэй.

92. 2009 – 2013 онд 10.3 мянган хүүхэд дотоодод, 49 хүүхэд гадаад улсын гэр бүлд үрчлэгдсэн байна.

93. Гэр бүлийн тухай хуулиар дотоодод хүүхэд үрчлэх асуудлыг тухайн сум,



дүүргийн Засаг дарга, гадаадад хүүхэд үрчлэх асуудлыг журмын дагуу шийдвэрлэж байна. Дотоод үрчлэлийн шалтгаан нөхцөл олон янз байдаг. Аймаг, нийслэлийн тайлангуудад зарим анхаарал татсан асуудлыг дурдсан байна. Тухайлбал, Хүүхэд үрчлэлт нь мөнгөний ашиг сонирхолтой байх, олон хүүхэд өсгөсний тэтгэвэрт гарах, Алдарт эхийн одон авах, одонгийн мөнгө авах зэрэг зайлшгүй бус шалтгаанаас гадна оюутан хүүхдийнхээ хүүхдийг нь өөрсдийн нэр дээр шилжүүлэх, огт хүүхэдгүй гэр бүлийн хувьд хүүхэдтэй болох зэргийг нэрлэжээ.

94. Гэр бүлийн тухай шинэчилсэн найруулгын үрчлэл нь хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцсэн байх механизмыг бүрдүүлэхээр тусгасан.

95. Гадаад үрчлэлд тавих Засгийн Газрын болон хөндлөнгийн хяналтын асуудал орхигдсон хэвээр байна. Мөн хүүхдийн үрчлэл эрхэлсэн зөвлөл нь зөвхөн төрийн байгууллагын төлөөлөөс бүрдэхээр хуулийн төсөлд тусгасан байгааг иргэний нийгмийн байгууллагууд шүүмжилж байна.

### **Зургаа. Эрүүл мэнд ба нийгмийн халамж**

#### **Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүнд чиглэсэн нийгмийн үйлчилгээ**

96. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай хуульд 2013 онд хүүхдийн эрх ашгийг хамгаалах талаар нэмэлт өөрчлөлт орууллаа. Өөрчлөлтийн дагуу 18 хүртэл насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоодод хийлгэсэн протезийн үнийг эдэлгээний хугацаа дууссан болон тухайн хүүхдийн өсөлтийн улмаас бие эрхтэнд нь таарахгүй болсон тохиолдолд тухай бүрд 100 хувь нөхөн олгох үйлчилгээнд 2013 оны байдлаар 1788 хүүхэд хамрагдаж, нийгмийн халамжийн сангаас 892,7 сая төгрөг зарцуулсан байна. Эдгээр протезийн хэрэгслийн дотроос тулах, хөдлөх эрхтний буюу шилбэний протез, өвдөгний тулгууртай шилбэний протез гэх мэт протезийн хэрэгслийг түлхүү хийлгэж байгаа нь хүүхдийн дунд осол гэмтлийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй болох тохиолдол цөөнгүй байгааг харуулж байна. 18 хүртэл насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүнчлэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн болон худалдан авсан ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийг 3 жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгох үйлчилгээнд 6865 иргэн хамрагдаж, 1,1 тэрбум төгрөг зарцуулсан байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн цэцэрлэг сургуульд ирж, очих унааны зардлыг жилд нэг удаа хөнгөлөх эсвэл автобусаар үйлчлэх үйлчилгээний жилд олгох мөнгөн дүнгийн хэмжээ 200,000 төгрөг бөгөөд уг үйлчилгээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг суралцах эрхийг хангахад тодорхой хэмжээний дэмжлэг болж байна. Уг үйлчилгээнд 2013 онд 991 хүүхэд хамрагдаж, 273,9 сая төгрөг зарцуулсан байна. Бүрэн хараагүй, бүрэн хэлгүй дүлий, одой иргэн болон байнгын асаргаа шаардлагатай хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох үйлчилгээнд 2013 онд 17,853 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдаж,

нийгмийн халамжийн сангаас 2,9 тэрбум төгрөг зарцуулсан байна.

97. Монгол Улсын нийт хүн амын 4,1 хувийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эзэлдэг бол тэдний 20 орчим хувийг сэтгэцийн эмгэгтэй иргэд эзэлдэг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр 304 төрийн бус байгууллага ажиллахаар бүртгүүлснээс 80 гаруй нь тогтмол үйл ажиллагаа явуулж байна. ҮСХ, ЭМЯ хамтран “Хүүхэд хөгжил-4” судалгаагаар илрүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог магадлах нэмэлт судалгааг 2013 – 2014 онд явуулж, статистикийг баталгаажуулсан байна.

#### **Хүүхдийн эрүүл мэнд**

98. УИХ-аас 2011 онд шинэчлэн баталсан Эрүүл мэндийн тухай хуульд 18 хүртэл насны хүүхдэд төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг төр хариуцахаар тусгажээ. Энэхүү хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд харьяа анхан, дунд шатны эрүүл мэндийн төвийн байнгын хяналтад байж тусламж, үйлчилгээ авах, 16 хүртэл насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эмийн зардлыг төр хариуцах, өрх, сумын эрүүл мэндийн төвд хүүхдийн мэргэшсэн эмч ажиллуулах ба энэ эмч нь шаардлагатай үед дуудлагаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэрт нь тусламж, үйлчилгээ заалтыг нэмж тусгасан.

99. МУЗГ 2012 онд. “Эрүүл хүүхэд” аян өрнүүлж 18 хүртэл насны хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, эрүүл мэндийн байдлыг үнэлэх, эмгэг илэрсэн хүүхдийг мэргэжлийн эмчийн хяналтад авах, цаашид эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулсан. Аяны хүрээнд эрүүл мэндийн 67 салбар нэгжийн 6200 гаруй эмч, ажилтан, судлаачид ажиллан, нийт хүүхдийн 83,6 хувийг эрүүл мэндийн аяны үзлэгт хамруулж, тэдний 97,5 хувийн мэдээллийг нэгдсэн санд тусгажээ. Үзлэгээр хүүхдийн 57 хувь нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ шаардлагатай бөгөөд 45 хувьд нь хоол боловсруулах тогтолцооны, 20 хувьд нь амьсгалын тогтолцооны өвчин зохилон тохиолдсон байна.

#### **Эх, нярайн эрүүл мэнд**

100. Засгийн Газраас эх, хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах чиглэлээр “Эх, нярайн эрүүл мэнд 2011 –2015” үндэсний стратеги, “Эхийн эндэгдлийг бууруулах стратеги” (2001–2004, 2005–2010) “Хүүхдийн эсэн мэнд амьдрахуй (2012–2015)” үндэсний стратеги, “Эх хүүхдийг бичил бодис, амин дэмийн дутлаас сэргийлэх стратеги”, “ХДХВ/ДОХ –той эхээс төрсөн хүүхдийн тусламж үйлчилгээний удирдамж”, “Төрөлхийн тэмбүүгээс сэргийлэх стратеги”, ядуу эмзэг бүлгийн эх хүүхдэд чиглэсэн “Дүүрэг бүрт хүрч үйлчилэе”, “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний IV дэх хөтөлбөр, “Хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх үндэсний стратеги (2014–2016)” ийг батлан хэрэгжүүлж байна. Эхийн эндэгдлийн түвшин 100 000 амьд төрөлтөд 1992 онд 204 байсан бол 2004 онд 98,8 болж, Монгол Улс эхийн эндэгдэл өндөртэй орноос эхийн эндэгдэл дунд зэрэгтэй орон болсон бөгөөд 2013 онд энэ үзүүлэлт 42,6 болсон байна. Эх хүүхдийн тусламжийг анхан шатны эрүүл мэндийн байгууллага болох өрх, сумын эрүүл мэндийн төв, аймаг, дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Эх хүүхдийн эрүүл мэндийн төв зэрэг 3 шатлалаар үзүүлж байна. Өрх, сумын эрүүл мэндийн төвийн үүрэг нь гэр бүл төлөвлөлт, жирэмсний хяналт, эрсдэлтэй болон жирэмсний хүндрэлтэй эхчүүдийг дээд шатлалын эмнэлэгт

шилжүүлэх, хэвийн жирэмсэн болон төрсний дараа эх, хүүхдийн эрүүл мэндийг хянах, бага насны хүүхдийн өсөлт хөгжилтийг дэмжих, эрүүл хүүхдийн хяналт, хүүхдэд зонхилон тохиолдох өвчнүүдийн үед цогц тусламж үзүүлэх, дархлаажуулалтад хамруулах зэрэг асуудал юм. 2010 оноос жирэмсэн эхчүүдэд “Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийг олгож, хүүхдийг төрсний дараа энэхүү дэвтрийн дагуу хянаж байгаа нь гэр бүлд төвтэй эх хүүхдийн тасралтгүй тусламж үйлчилгээний нэг хэлбэр болж амжилттай хэрэгжиж байна. Жирэмсэн эмэгтэйчүүдэд жирэмсний бүхий л хугацаанд 6 удаа хяналтад үзүүлэх стандартыг баримталж байгаа ба үүнд дараах үйлчилгээ, зөвлөлгөө үзүүлж хянаж байна.

101. Гэр бүл төлөвлөлт, жирэмсний эрт хяналт, эрсдэлтэй болон жирэмсний хүндрэлтэй эхчүүдийг дээд шатлалын эмнэлэгт шилжүүлэх, хэвийн жирэмсэн болон төрсний дараа эх, нярайн эрүүл мэндийг хянах, бага насны хүүхдийн өсөлт хөгжлийг дэмжих, вакцинжуулах зэрэг үйл ажиллагааг өрх, сумын эрүүл мэндийн төвүүд хариуцаж байна. 2010 оноос хүүхэд бүрт “Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр” ашиглах болов. Эмэгтэйчүүдийг жирэмсний хяналтад ороход нь дараах үйлчилгээ, зөвлөлгөөг үзүүлж, тогтмол хянаж байна. Үүнд: цус, шээсний ерөнхий шинжилгээ, цээжийг гэрэлд харах, чанд авиан шинжилгээ (ЭХО), Мазокийн шинжилгээ, сайн дурын үндсэн дээр тэмбүү болон ХДХВ/ДОХ-ыг илрүүлэх шинжилгээ г.м байна.

#### **Хоол тэжээл**

102. 2011 оноос 5 хүртэл насны хүүхдийг өсөлтийн хяналтад тогтмол хамруулж, “Хүүхдийн өсөлтийг дэмжих” интервенц хэрэгжүүлсэн нь хүүхдийн хоол тэжээлийн дутлаас үүдэлтэй тураал, болон өсөлтийн хоцролтыг бууруулахад чухал алхам болсон. “Хүүхэд хөгжил” судалгааны дүнгээс харахад тав хүртэл насны хүүхдийн дунд өсөлтийн хоцролт 15.3%, тураал 3.3%, туранхай 1.6% байна. Хүүхдийг 6 сар хүртэл эхийн сүүгээр дагнан хооллох үзүүлэлт сүүлийн 10 жилийн хугацаанд харьцангуй тогтвортой (50–60%) түвшинд байгаа ба аминдэм, бичил бодисын дутлын үзүүлэлт төдийлэн сайн буурахгүй байна. 5 хүртэл насны хүүхдийн дунд цус багадалт 28.5%, төмрийн дутал 21.4%–тай байна. Д аминдэмийн дуталд 5 хүртэл насны хүүхдийн 21.8% нь өртсөн бол А аминдэмийн дуталд 32.4% нь өртсөн байна. Хүүхдийн нэмэгдэл хоолны нэр төрөл өмнөх судалгаатай харьцуулахад олширсон байна. 6–59 сартай хүүхдийн хоол хүнсний бүтцэд гурил, мах, будаа, сүүн бүтээгдэхүүн давамгайлсан хэвээр байна.

#### **Өсвөр насны хүүхдийн эрүүл мэнд**

103. Улсын Их Хурал “ХДХВ/ДОХ–оос сэргийлэх тухай”, “Сэтгэцийн эрүүл мэндийн тухай” болон “Тамхины хяналтын тухай” хуулийг шинэчлэн баталлаа. Эдгээр хууль нь өсвөрийн үеийнхний эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээг сайжруулах, болзошгүй эрсдэлийг бууруулахад ихээхэн ач холбогдолтой юм. Монгол Улс “Өсвөр үе, залууст ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээ”–г бодлогын тэргүүлэх чиглэл болгодог бөгөөд 2013 оны байдлаар улсын хэмжээнд 14 аймаг, нийслэлийн 5 дүүрэгт Өсвөр үеийнхэнд ээлтэй клиник ажиллаж байна. 2013 онд Эрүүл мэндийн яамнаас “Өсвөр үе, залууст ээлтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ”–ний цогц стратегийг боловсруулж, энэхүү үйлчилгээг бусад аймаг дүүрэгт өргөжүүлэхээр түншлэгч байгуулагуудтай хамтран

ажиллаж байна.

104. ХДХВ/ДОХ-оос сэргийлэх тухай хуулийг 2012 онд шинэчлэхдээ хүний эрхийг хамгаалах, ялангуяа хувь хүний нууцыг хүндэтгэх заалтууд нэмж, албадлагын шинжтэй заалтыг хассан. Монгол Улсад /2014 оны эхний хагас жилийн байдлаар/ ХДХВ-ийн халдвар насанд хүрэгчдийн дунд 0.1 хувиас бага тархсан бөгөөд ХДХВ-ийн халдвартай 177 хүн байна.

105. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар тамхины хэрэглээ, дам тамхидалтаас хүн амыг хамгаалах эрх зүйн орчинг сайжруулж, сургуулийн орчинд 500 м-ийн дотор тамхи зарах, 18 нас хүрээгүй хүнд тамхи худалдах, түүгээр тамхи худалдуулахыг хориглосон. “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2013” судалгааны дүнгээр 15–49 насны эрэгтэйчүүдийн 17.2 хувь, харин 15–49 насны эмэгтэйчүүдийн 0.8 хувь нь 15 нас хүрэхээс өмнө тамхи татаж үзжээ. Дээр дурдсан судалгааны дүнгээс харахад Монгол Улсад эрэгтэйчүүдийн дунд архи, согтууруулах ундааны хэрэглээ эмэгтэйчүүдтэй харьцуулахад илүү байна. Эмэгтэйчүүдийн 20.9 хувь нь архи огт ууж үзээгүй байхад 0.8 хувь нь 15 нас хүрэхээсээ өмнө архи, согтууруулах ундаа ууж үзжээ.

### **Долоо. Боловсрол, чөлөөт цаг, соёлын арга хэмжээ**

#### **Боловсролын үйлчилгээ**

106. Боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай хуульд оруулж байгаа нэмэлт, өөрчлөлтийн нь олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн өрсөлдөх чадвартай, чанартай боловсролын үйлчилгээг бий болгох; ерөнхий боловсролын сургалтыг 5+5+2 гэсэн бүтэцтэй болгох; институцид суурилсан боловсролын мэргэжлийн байгууллагын тогтолцоог бэхжүүлж боловсролын чанарын баталгааг хангах; ерөнхий боловсролын сургуулийн хэв шинжийг өөрчлөх; цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоол, хүнсний үйлчилгээний эрүүл, аюулгүй байдлыг хангах; боловсролын тасралтгүй хөгжлийг хангах идэвх чармайлтыг нэмэгдүүлэх; шинээр барих цэцэрлэг, сургуулийн барилга, газрын төлөвлөлт хийх харилцааг зохицуулах; гадаад орны боловсролын баримт бичгийг хүлээн зөвшөөрөх зэрэгт чиглэж байна.

107. Боловсролын хүртээмжийг сайжруулах чиглэлээр: 2008–2011 онд ерөнхий боловсролын сургуульд ажиллаж буй мэргэжлийн багшийн хангалт 1.9 хувиар, сурагчдын дотуур байранд хамрагдалт 4,5 хувиар тус тус өсч, бүлэг дүүргэлт 1.5–аар буурлаа. Түүнчлэн бага ангийн сурагчдыг “Үдийн цай” хөтөлбөрт хамруулах, эмзэг бүлгийн өрхийн хүүхдийг хичээлийн хэрэгслээр хангах ажлыг үргэлжлүүлэн, төрөөс сурагчдыг сурах бичгээр хангах, дотуур байрны хамрагдалтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд бага боловсролын хамран сургалтын цэвэр жин 2008 онтой харьцуулахад 3,3 хувиар өсч 94.8%, бохир жин 98.1 хувь, суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин 2.4 хувиар өсч 89.8% боллоо.

#### **Сургуулийн өмнөх боловсрол**

108. Сургуулийн өмнөх боловсролыг хүүхэд бүрт заавал эзэмшүүлэхээр хуульчлаагүй боловч Засгийн Газар сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг

нэмэгдүүлэх, сургалтын орчныг сайжруулахад чиглэсэн бодлогын арга хэмжээг хэрэгжүүллээ. Төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх бодлогыг тууштай баримталж ирснээр багагүй ахиц гарлаа. Тухайлбал, 2011–2012 оны хичээлийн жилийн байдлаар 2007–2008 оны хичээлийн жилийнхээс төрийн өмчийн цэцэрлэгийн тоо 68–аар нэмэгдэн 734–д, хувийн хэвшлийн цэцэрлэгийн тоо 43–аар өсч 145–д хүрлээ. Монгол улс 2011–2012 оны хичээлийн жилийн байдлаар 879, 2012–2013 оны хичээлийн жилд 1017 цэцэрлэгтэй байна.

109. Цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдийн тоо 2011–2012 оны хичээлийн жилд өмнөх оноос 11.2 мянгаар өсч, 133351–д хүрэв. Мөн хувилбарт сургалтад 30912 хүүхдийг хамруулсан. Энэ бүхний дүнд сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 2011–2012 оны хичээлийн жилийн байдлаар цэвэр жингээр 70.8%, бохир жингээр 74,9% болж, энэ нь цаашид жил бүр нэмэгдэж байна.

110. Засгийн Газар 2012 онд “Хоолны зардлын дундаж норматив батлах тухай” тогтоол баталснаар цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг 1100 төгрөгөөс 1650 төгрөг, тусгай болон сувиллын цэцэрлэгийнх 1100 төгрөгөөс 2400 төгрөг, 24 цагийн цэцэрлэгийнх 1600 төгрөгөөс 2400 төгрөг, дотуур байрны хүүхдийн хоолны зардал 1545 төгрөгөөс 2315 төгрөг, Үдийн цайны зардал 400 төгрөгөөс 600 төгрөг болгон нэмэгдүүлж, 2013 оны 01–р сарын 01–ны өдрөөс эхлэн мөрдөж байна. Цэцэрлэгийн хүүхдийн хоолны цэсийг шинэчлэх, хоол хүнсний шим тэжээл, өсөлт, хөгжлийн хамаарлыг тооцох аргачлалыг шинэчлэн боловсрууллаа.

### **Ерөнхий боловсролын сургууль**

111. 2013–2014 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургууль 12 жилийн сургалтын тогтолцоонд бүрэн шилжлээ. Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд 6 настай хүүхдийг сургуульд элсүүлэн сургах бэлтгэлийг хангах, 12 жилийн сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулах, сурах бичиг, гарын авлагыг шинэчлэх зэрэг олон талт арга хэмжээг авав.

112. Зургаан настай хүүхдийг сургуульд элсүүлэн сургах бэлтгэлийг хангах ажлын хүрээнд нэгдүгээр ангид хичээл заах багш нарыг бэлтгэх сургалтыг 4 жил дараалан зохион байгуулж, нийт 6818 багш, мөн 501 дотуур байрны багш, 624 нийгмийн ажилтныг тус тус хамруулаад байна. Эдгээр сургалтын үр дүнд бага ангийн нийт багшийн 75,3% нь 6 настай хүүхэдтэй ажиллах арга зүйд суралцсан байна. 2012 онд 6 настай хүүхдэд хичээл заах 1800 багшийг бэлтгэснээр бага ангийн бүх багш дээрх арга зүйгээр хангагдах болно.

113. Ерөнхий боловсролын 12 жилийн сургалтын хөтөлбөрүүдийг шилжилтийн графикийн дагуу боловсруулан баталгаажуулж, шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмжийг боловсруулан хэвлэж, түгээх болон багш нарыг заах арга зүйгээр хангах хоёр үе шаттай сургалтыг жил бүр зохион байгуулснаар 2008–2011 онд 84 хөтөлбөр, зөвлөмжийг нийт 76000 хувь хэвлэн 4 жилд давхардсан тоогоор нийт 57.2 мянга гаруй багшийг сургалт, семинарт хамруулав.

114. Сурах бичгийг шинэчлэх ажлын хүрээнд шилжилтийн хуваарийн дагуу ерөнхий боловсролын сургуулийн 12 жилийн сургалтын хөтөлбөрт нийцсэн сурах бичгийг боловсруулан, хэвлүүлж, тухайн хичээлийн жил эхлэхээс өмнө түгээх ажлыг бүрэн

хэрэгжүүлдэг болсон бөгөөд шинэ сурах бичгүүдийг цахим хуудсанд байрлуулж байна. Ерөнхий боловсролын сургуулиудыг хөгжим, биеийн тамирын хичээлийн хэрэгслээр үе шаттай хангах ажлыг төлөвлөж 2009–2012 онд 937.0 сая төгрөгийн хөгжмийн зэмсэг, 614.6 сая төгрөгийн биеийн тамирын хэрэгсэл авч сургуулиудад нийлүүлэв.

115. Дэлхийн 46 улс оронд сургуулийн насны 11474 монгол хүүхэд эцэг эхийн хамт амьдарч байна. Гадаадад сурч амьдарч байгаа хүүхдэд зориулж сурах бичгийг цахим хэлбэрт оруулж, веб хуудсанд байршуулснаар эх хэл, соёлоо судалж суралцах боломжийг бүрдүүлж байна.

### **Боловсролын байгууллагын хангамж, хүний нөөц, тэгш байдал**

116. Засгийн Газар 2013 онд Багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам баталлаа. Журамд сургууль, цэцэрлэгийн багшаас хүүхэд бүрийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх, төлөвшүүлэх, сургалтын чанарыг сайжруулах, хүүхдэд ээлтэй эрүүл орчин нөхцөл бүрдүүлэх чиглэлийн бүтээлч ажлын ахиц, амжилтаа 5 төрлийн 12 шалгуур үзүүлэлтээр үнэлүүлж, үр дүнгээ тооцуулан урамшуулал авахыг тусгасан.

117. “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх” журам шинээр баталсан нь ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн багш, ажилтан (захирал, эрхлэгч, сургалтын менежер, нийгмийн ажилтан, арга зүйч, дотуур байрын багш, номын санч, туслах багш)–ын заах арга барил, хандлагыг өөрчлөхөд их ач холбогдолтой болсон. 1, 5, 10 жил ажиллаж байгаа багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр журамд тусгажээ.

### **Чанартай боловсрол**

118. Улсын хэмжээнд (2012–2013 оны хичээлийн жилд) нийт 945 хүүхдийн цэцэрлэг байгаа нь 2009 оноос цэцэрлэгийн тоо 15 орчим хувиар нэмэгдсэн байна.

119. Улсын хэмжээнд (2012 оны байдлаар) 655 гэр цэцэрлэг ажиллаж байна. Азийн Хөгжлийн банкны “Хөдөөгийн болон шилжин суурьшсан иргэдийн хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох”, Дэлхийн Банкны “Боловсролын түншлэл” төслийн хүрээнд гэр цэцэрлэгт, тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, тоглоом наадгай, цахилгааны эх үүсвэрийг нийлүүлсэн байна. Түүнчлэн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр аймаг, орон нутаг өөрсдөө шинээр цэцэрлэг барих, гэр цэцэрлэг байгуулах санаачилга гаргаж байна. Тухайлбал, Орхон аймаг орон нутгийнхаа төсвөөс 502,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэснээр 280 хүүхдийн “Оюу”, “Дэгдээхий”, 140 хүүхдийн “Бялзуухай” цэцэрлэг байгуулж, тус аймгийн 18 дугаар цэцэрлэгт 100 хүүхдийн өргөтгөл ашиглалтад орлоо.

120. Улсын хэмжээнд, 2012–2013 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 755 сургууль байгаагийн 82.3 хувь нь төрийн өмчийн, 17.7 хувь нь хувийн сургууль бөгөөд төрийн өмчийн нийт сургуулийн 81.6 хувь буюу 507 нь хөдөөд, 18.4 хувь буюу 114 нь нийслэлд байна. Нийт сургуулийн 7.3 хувь нь бага сургууль, 18.3 хувь нь дунд, 68.2 хувь нь ахлах сургууль, 6.2 хувь нь цогцолбор сургуулийн ангилалд багтаж байна.

121. Улсын хэмжээнд (2012–2013 оны хичээлийн жилд) ерөнхий боловсролын сургуульд 17,6 мянган бүлэг хичээллэж байна. Ерөнхий боловсролын сургуулийн нийт

бүлгийн 62.7 хувь нь нэгдүгээр ээлжид, 36.5 хувь нь хоёрдугаар ээлжид, 0.8 хувь нь гуравдугаар ээлжид хичээллэж байна. Энэ хичээлийн жилд бага ангийн нийт бүлгийн 91.2 хувь (8,110) нь, дунд ангийн бүлгийн 100.0 хувь (5,334), ахлах ангийн бүлгийн 23.1 хувь (785) нь тус тус 12 жилийн сургалтын хөтөлбөрөөр хичээллэж байна.

122. 2012–2013 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд нийт 498.0<sup>2</sup> мянган (өдрөөр 496,123, оройгоор 617, эчнээгээр 1,242) суралцагч өдөр, орой, эчнээ хэлбэрээр суралцаж байна. Өдрөөр суралцагчдын 50,2% охид, 49,8% нь хөвгүүд байна. Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын хүйсийн харьцаа сүүлийн жилүүдэд тэгширч байна.

123. 2012–2013 оны хичээлийн жилд 6–14 насны 2332 хүүхэд (40,1% нь охид, 59,9 нь хөвгүүд) сургууль завсардсан байна. Сургууль завсардалтын шалтгааныг авч үзвэл 35,8% нь амьдралын гачигдлаар, 7,7% нь сурах дургүйгээс, 3,0% нь ажил эрхлэхээр, 34,9% нь өвчний улмаас, үлдсэн 18,5% нь тодорхой шалтгаангүй байна. Сургууль завсардсан нийт хүүхдийн 35,2% нь Баян–Өлгий аймагт байгаагийн 40,9 хувь нь амьдралын гачигдлаар, 36,4 хувь шалтгаан тодорхойгүй байна. Сургуулийн гадна байгаа нийт хүүхдийн 54,3 хувь нь сургуульд ороогүй завсардсан бол үлдсэн 55,7 хувь нь сургуульд ороод завсардсан байна.

124. Засгийн Газрын шийдвэрээр 2009 оноос эхлэн ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдад 100 хувь, дунд ахлах ангийн сурагчдад 40 хувь сурах бичгийг сургуулийн номын сангаар дамжуулан үнэ төлбөргүй хэрэглэх ажлыг зохион байгуулж ирлээ. Бага ангид хүүхэд бүрийн сурах бичгийг төрөөс хариуцаж, дунд, ахлах ангийн бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн болон ерөнхий боловсролын сургуульд 3 буюу түүнээс дээш хүүхэд нь суралцдаг өрхийн хүүхдийн сурах бичгийг үнэ төлбөргүйгээр хангаж байна.

125. “Үдийн цай” хөтөлбөрт (2012 онд) ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн 258.0 мянган хүүхэд хамрагдаж, үдийн цайны зардалд 16.7 тэрбум төгрөг зарцуулагджээ.

*Хүснэгт 20. Хөтөлбөрт хамрагдагчдын тоо болон санхүүжилтийн хэмжээг дараах хүснэгтээр үзүүлэв:*

Хичээлийн жил	Анги	Нэг хүүхдийн хоолны зардал /төгрөгөөр/	Хамрагдсан хүүхдийн тоо	Санхүүжилт /тэрбум төгрөгөөр/
2007–2008	I–IV	400	187863	16.5
2008–2009	I–V	400	252600	18.5
2009–2010	I–V	400	280407	19.1
2010–2011	I–V	400	265700	16.1
2011–2012	I–V	400	255900	16.7

*БШУЯ–ны мэдээ, 2013.*

<sup>2</sup> Өдөр, орой, эчнээгээр суралцагчдын тоо

126. Засгийн Газар 2011 онд ерөнхий боловсролын сургуулийн хоол хүнсний үйлчилгээтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэх, үдийн цайны үйлчилгээг үдийн хоолны үйлчилгээ болгон өргөжүүлэх зорилгоор "Хөтөлбөр хэрэгжүүлэх бэлтгэл ажлын тухай" тогтоол гаргав. Энэ тогтоолын дагуу "Үдийн хоол" хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжийг Шинжлэх Ухаан Технологийн Их сургуулийн Хүнсний инженер биотехнологийн сургуулийн мэргэжлийн багт түшиглэн байгуулж, Дархан-Уул, Орхон, Архангай аймаг болон Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 58 дугаар сургуульд хоол, хүнсний үйлдвэрлэлийн газар байгуулав. "Үдийн хоол" хөтөлбөрийн бэлтгэл ажлын төлөвлөгөөг БСШУ-ы сайд баталж, сургууль, дотуур байрын гал тогооны техник, тоног төхөөрөмжийг сайжруулах ажлыг үе шаттайгаар гүйцэтгэж байна. 2012 онд 47.5 орчим сая төгрөгийн үнэ бүхий 20-иод нэр төрлийн гал тогооны 21 тоног төхөөрөмжийг дунд сургуулийн 40 орчим хувьд нь нийлүүлж, 2013 онд дээрх тоног төхөөрөмжид 2,4 тэрбум төгрөг төлөвлөсөн байна.

127. Засгийн Газраас дүрэмт хувцсаар сурагчдыг хангах ажлыг Оёдлын нэгдсэн холбооны салбар 67 оёдлын үйлдвэр, 38 сүлжмэлийн үйлдвэртэй хамтран хэрэгжүүлж байна. 1-5 дугаар ангийн нийт сурагчдыг шинэ дүрэмт хувцсаар хангалаа. Энэ нь сургуулийн насны хүүхдийн тэгш байдлыг хангах, ялгаварлал гарахаас урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой юм.

### **Дотуур байрны хүрэлцээ**

128. Монгол Улсад (2013 оны хичээлийн жилд) ЕБС-ийн 506 дотуур байранд нийт 36130 хүүхэд амьдарч байна. Эдгээр хүүхдийн 52,2 хувь нь охид байна. 2009 оноос хойш сурагчийн дотуур байрны хүчин чадлыг өргөтгөж байгаа ч байранд амьдарч байгаа хүүхдийн тоо 6000 орчмоор багассан байна. Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд шинээр 7 байр ашиглалтад орж, орны тоог 1060-аар нэмэгдүүлэв. Дотуур байрны 30 барилгад 8.6 тэрбум төгрөгийн засварын ажил хийж, 45 сургуулийн дотуур байрны зөөлөн эдлэл, гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчиллээ. Цаашид шинээр 120 дотуур байр буюу 9845 хүүхэд хүлээн авах дотуур байрны хэрэгцээ байгааг БШУЯ судалж гаргасан байна.

129. Ховд аймаг "Хүүхдэд ээлтэй дотуур байр"-ны 29 үзүүлэлт бүхий өөрийн үнэлгээний аргачлалд суурилсан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулаад ажиллаж байна.

130. Нэгдүгээр ангид орох 6 настай хүүхдийн сургуульд хамрагдалтын цэвэр жин<sup>3</sup> 2009 онд 91,1 хувь байсан 2013 онд 97,6 хувь болж өссөн ч элсэх ёстой насны хүүхдийн 2,4 хувь нь сургуульд суралцах насандаа сургуульд элсэн ороогүй байна. Үүний дийлэнх хувь нь малчдын хүүхэд байгаа юм.

131. Тайлант хугацаанд боловсролын салбарт улсын төсвөөс 31.2 мянган суудалтай 74 сургуулийн хичээлийн байр, 4.0 мянган ортой 35 дотуур байрны барилга, 35 спорт заалны барилгыг шинээр барьж ашиглалтад оруулсан бөгөөд үүнд 120.2 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Гадаад орон, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, зээлийн хөрөнгөөр 3.9 мянган суудалтай 9 сургуулийн барилгыг шинээр барьж тавилга,

<sup>3</sup> 6 настай хүүхдийн сургуульд хамрагдалт



тоног төхөөрөмжийн хамт нийлүүлсэн бөгөөд үүнд 35.6 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

*Хүснэгт 19. Шинээр нэмэгдсэн хичээлийн байр, суудлын тоо*

Он	2009	2010	2011	2012	дүн
Хичээлийн байр	18	13	15	28	74
Суудлын тоо /мянга/	5,9	4.7	5,6	15.0	31.2

*БШУЯ–ны мэдээ, 2013.*

**Боловсролын тусгай үйлчилгээ**

132. Цэргийн насны залуусын бичиг үсгийн боловсролыг ахиулах, боловсрол нөхөн эзэмшүүлэх асуудлаар судалгаа хийж, Албан бус боловсрол, зайны сургалтын Үндэсний төв (2013 оноос Насан туршийн боловсролын төв гэх болсон) өөс бичиг үсгийн гурван шатны сургалтын хувилбарт гарын авлага боловсруулж, Албан бус боловсролын “Гэгээрэл” төвүүдэд түгээн сургалтад ашиглаж байна. 2010–2011 оны хичээлийн жилийн байдлаар 45 төрлийн 153 хэвлэлийн хуудас сурах бичиг, гарын авлага, амьдрах аж төрөх ухааны 50 төрлийн гарын авлага, 8 цуврал радио хичээл, 12 төрлийн видео хичээл бэлтгэн түгээжээ. Эдгээр олон хувилбарт сургалтын материалын онцлог нь амьдрах ухааны агуулгад суурилсан бөгөөд насанд хүрэгчдийн сурах арга барилд тохируулснаараа ач холбогдолтой байлаа.

133. *Монгол Улсын 15–аас дээш насны хүн амын бичиг үсэг тайлагдалтын түвшин 98,3 хувь байгаа олон улсын түвшинтэй харьцуулахад өндөр.* Гэвч Дүйцсэн хөтөлбөрөөр 2009–2010 онд 11668, 2011–2012 онд 12200, 2012–2013 онд 11810 хүн суралцаж, нөхөн боловсрол эзэмшсэний 70 орчим хувь нь хөвгүүд байна. Өнгөрсөн хугацаанд шинээр барьсан болон засварлаж ашиглалтад орсон 30 сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах гадаад орчны болон сургалтын нөхцөлийг бүрдүүлэв.

**Боловсролын орчин дахь хүүхэд хамгаалал**

134. Сургуулийн нийгмийн ажилтанд 2013 оноос эхлэн мэргэжлийн зэрэг, нэмэгдэл цалин олгох шийдвэр гарснаар тэдний цалин 15 –20 хувиар нэмэгдэж, хүний нөөцийн чадавх сайжирч, сурагчдын нийгмийн асуудал шийдэгдэхэд нөлөөлөх болов.

135. Нийслэлийн хэмжээнд сурагчдын замын хөдөлгөөнд оролцоход аюулгүй байдлыг хангах зорилгоор нийт 5 дүүргийн 34 сургууль 104 автобусаар өөрийн сургуулийн 3424 суралцагчдад зохион байгуулалттай тээврийн үйлчилгээ үзүүлж, Сонгинохайрхан дүүргийн нийт 12 сургуулийн сурагчдад тусгай маршрутын автобусаар үйлчлүүлэх ажлыг зохион байгууллаа.

136. 2013 оноос эхлэн Нийслэлийн ИТХ–ын шийдвэрийн дагуу бүх дүүргийн 154 сургуульд “Sckool Policy” эргүүлийн хөдөлгөөн өрнөж, 48217 эцэг эх сургуулийн орчинд үйлдэгдсэн 1500 хэрэг зөрчлийг илрүүлж, 460 гаруй удаа урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан байна.

**Амралт, чөлөөт цагийн үйлчилгээ**

137. Хүүхдийн амралт, чөлөөт цагийн үйлчилгээ, хөгжлийн асуудалд БСШЯ, ХАХНХЯ, ССАЖЯ тэргүүлэх чиг үүрэгтэй хандаж, орон нутгийн хурал, захиргаа, бизнесийн байгууллагууд хамтран ажиллаж байна.

138. Засгийн Газар 2012 онд 7, 2013 онд 5 тэрбум төгрөгийг соёл урлаг хөгжүүлэх сангаар дамжуулан, хүүхэд, залуучуудын соёл, урлагийн чиглэлээр боловсрол эзэмших, сургалтад хамрагдах, олон улсын болон дотоодын уралдаан, тэмцээн, үзэсгэлэнд оролцоход зарцуулах, хүүхдэд зориулсан уран бүтээлийг дэмжихэд зориулсан байна. Үндэсний урлагаа хөгжүүлэх зорилгоор “Монголын уламжлалт бүжиг бий биелгээ”, “Монгол тууль”, Морин хуур, уртын дуу” хөтөлбөрийг хэрэгжүүлж, үүнд оролцогч, эхлэн суралцагчдын зонхилон хэсэг нь хүүхэд байна.

139. Засгийн Газар 2012–2016 оны хөрөнгө оруулалтын жагсаалтыг боловсруулахдаа биеийн тамир, спортын салбарт 50 спорт цогцолбор, 72 спорт зал, 29 соёл, спортын төв, 41 хүүхэд залуучуудын соёл, спорт, амралтын хүрээлэн байгуулахаар төлөвлөөд хэрэгжүүлэх ажлаа зохион байгуулж байна.

140. Өсвөр насны хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх гол төв нь цахим тоглоомын газар юм. Улаанбаатар хотод 500–700 орчим, аймаг бүрт тоглоомын үйлчилгээ эрхэлдэг 5–6 цахим нэгж ажиллаж байна. ХЗЯ, ЭМЯ, ХТҮГ зэрэг төрийн байгууллага хамтран, “Цахим тоглоомын газрын үйл ажиллагааг зохицуулах журам” боловсруулж, 2013 онд Засгийн Газраар батлуулаад мөрдөж байна. Тус журмаар цахим тоглоомын газрын ажиллах цаг, үйлчлүүлэх хүүхдийн насны доод хязгаар бий болов.

**Найм. Онцгой хамгааллын арга хэмжээ**

**Орогнол хүсэгч болон дүрвэгч хүүхэд**

141. Эх орноосоо дүрвэж цагаачилсны улмаас хамгаалал хүссэн хүүхдийн талаар албан ёсны мэдээ байхгүй байна. Харин Монгол Улсын хүн амын үндэсний цөөнх болсон казак иргэдийн нүүдэл, шилжилттэй холбоотой хүүхэд иргэншлээ сэргээх асуудал гарч байна. Казак иргэд оршин суудаг Баян–Өлгий аймгаас зарим иргэн Монгол Улсын иргэний харьяаллаас гарч, Бүгд Найрамдах Казакстан улсад очиж, тэндэхийн иргэншил авсны дараа Монгол Улсад буцаж ирэх тохиолдол байна. Монгол Улс давхар иргэншлийг хүлээн зөвшөөрдөггүй тул Казакстан улсад төрсөн болон тэндэхийн харьяалал авсан хүүхдийн хувьд гэр бүлээрээ иргэний харьяаллаа сэргээх, эсвэл шинээр бүртгүүлэх асуудал тулгарч байна. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны мэдээгээр 2013 онд харьяатын асуудал нь шийдэгдээгүй 83 хүүхэд Баян–Өлгий аймагт байсан байна. Эдгээр хүүхдийг Ерөнхийлөгчийн 6 удаагийн зарлигаар Монгол Улсын харьяалал дахин оруулах шийдвэр гарчээ. Хэдийгээр энэ 83 хүүхдийн асуудал шийдэгдсэн ч харьяатаа сэргээлгэхээр хүсэлт гаргасан 10 гаруй хүүхдийн асуудал шийдвэрлэгдэх шатанд байна.

Монгол Улсад хууль бусаар ажиллаж байгаад албадан буцаагдсан гадаад иргэний тус улсад төрсөн, иргэний харьяалалгүй хүүхдийн асрамж хамгааллын асуудал гарч энэ асуудлын эрх зүйн зохицуулалтыг шаардаж байна.

**Эцэг эхээсээ тусдаа амьдарч байгаа хүүхэд**

142. Монголд хүүхэд урт богино хугацаагаар гэр бүлээсээ тусдаа амьдарч байна. Тухайлбал, дотуур байрны хүүхэд, тавиул хүүхэд, сүм хийдэд шавилан сууж байгаа хүүхэд, хараа хяналтгүй хүүхэд гэсэн бүлгийг дурдаж болно.

**Сургуулийн дотуур байрны хүүхэд**

143. Нүүдлийн мал аж ахуй эрхэлж, өргөн уудам нутагт тархан амьдардаг малчдын хүүхдийг боловсролд хамруулах үндсэн шийдэл нь дотуур байр байсаар ирлээ. 2012–2013 оны хичээлийн жилд улсын хэмжээнд 502 дотуур байранд 36130 хүүхэд амьдарч байснаас 90 гаруй хувь нь малчдын хүүхэд байна. Сургуулийн дотуур байранд хүүхдүүд хичээлийн жилийн турш буюу жил бүрийн 9 дүгээр сарын 1–нээс 6 дугаар сарын 1 хүртэл амьдардаг. Дунд нь нийтдээ гурван удаа нэг долоо хоногоос гурван долоо хоног хүртэл амарч гэртээ очдог. Улсаас дотуур байрны бүх зардал, хоол хүнсийг хангадаг.

144. 2008 оноос бага сургуульд орох насыг 6 нас болгосон нь бага насны хүүхдийн эрх ашиг, малчдын аж амьдралд гүнзгий нөлөөлжээ. 6 настай хүүхэд эцэг эхийн хайр халамжаас хол амьдрах, суралцах нь амаргүй тул малчин өрх, эцэг эх үр хүүхдийнхээ сургууль боловсролын төлөө зарим бэрхшээлтэй асуудалтай тулгарч байна. Залуу малчин гэр бүлийн хувьд 6 настай хүүхдээ боловсролд хамруулах энэ хэлбэр хүүхдэд болон гэр бүлийн амьдралд төвөгтэй байгааг 2014 онд хийсэн Залуу малчдын улсын зөвлөлгөөнд оролцогчид шүүмжилсэн байна.

145. 2014 онд ХТҮГ–аас “Сургуулийн дотуур байрны хүүхдийн хамгаалуулах эрхийн хэрэгжилтийн нөхцөл байдлын судалгаа” хийжээ. Судалгаанд хамрагдсан дотуур байрны хоёр хүүхэд тутмын нэг нь гадаад төрх байдал, хувцаслалт, амьжиргааны түвшин, сурлагын байдлаас хамаарч, нэр хоч авах, нэр төрөө гутаалгах асуудалд ордог гэжээ. Мөн айлган сүрдүүлэх /16,9 хувь/, зодох /12,5 хувь/, дооглох /22,9 хувь/, тохуурхах /14,3 хувь/, гадуурхах /17,9 хувь/, бүлэглэн гадуурхах /18,6 хувь/ зэрэг хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүд дотуур байранд байгааг гаргажээ. Хүүхдүүд учирдаг ялгаварлал, үе тэнгийнхний хүчирхийлэл, багш, бусад хүмүүсийн ширүүн харилцааны талаар санал гомдол гаргаж чаддаггүй талаар илэрхийлсэн байна.

**“Тавиул” буюу өөрийн өрх, гэр бүлээс гадна амьдарч байгаа хүүхэд**

146. Азийн гэр бүлийн соёлын нийтлэг уламжлал дагуу монгол хүмүүс ах дүү, төрөл төрөгсөд, гэр бүлийн гишүүдээ дэмжин тусалдаг өргөн уламжлалтай. Үүний нэг хэлбэр нь сургууль соёл зорьсон хүүхэд залуусаа төв, суурин газар амьдрахад нь тусалж, ах дүү, хамаатан садан төрлийн хүмүүс нь гэр орондоо суулгах, ойрхон байлгаж харж ханддаг явдал юм. Эмээ өвөө, хамаатан садан, гэр бүлийн найз нөхөд хүүхдийг сургуульд сурахад нь дэмжин, гэртээ амьдрах боломжоор хангадаг заншилтай. Энэ нь хүүхэд садан төрлийнхний асрамжид байх үндсэн боломжийг бүрдүүлдэг юм. ҮСХ хүн ам орон сууцны 2010 оны тооллогоор 18 хүртэл насны хүүхдийн 16.6 хувь нь гэр бүлээсээ тусдаа амьдарч байгааг гаргасан.

147. “Тавиул” хэлбэрээр амьдарч байгаа хүүхдийн үндсэн шалтгаан нь малчин айлын хүүхэд сургуульд сурахаар, төв, суурин газрын сургуульд чанартай боловсрол

эзэмшихээр болон эцэг эх нь өөр нутаг, оронд ажиллаж, амьдардаг, эсвэл салсан, эцэг эх нь хүүхдээ өөрийн аав ээж, ах дүүстээ орхиод сураггүй болсон, урт удаан хугацаагаар явсан, хурдан морь унаж, орлогоо нэмэгдүүлэхээр уяачийн гал дээр ирж амьдарсан, эцэг эх нь эсвэл аль нэг нь архины зэрэг хамааралтай болсон зэрэг асуудлаас үүддэг байна.

148. Тавиул хүүхдийн хувьд нийгмийн халамжид хамрагдах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахад зарим талаар багагүй хүндрэл үүсч байна. Иймд бусдын хүүхдийг түр хугацаагаар асран хамгаалж байгаа садан төрлийнхний асрамжийн үйлчилгээний уламжлалт нааштай энэ хэлбэрийг шинэ агуулгаар хөгжүүлэх, хүүхдэд үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд цаашид анхаарч хандах болно.

### **Хараа хяналтгүй хүүхэд**

149. 2012 оноос Нийслэлд байгаа хараа хяналтгүй хүүхдийг илрүүлэх, бүртгэх гурван удаагийн арга хэмжээнээс харахад 50–100 хүүхдэд тусгайлсан үйлчилгээг тогтвортой явуулах хэрэгцээ гарсан байна. Эдгээр хүүхэд гэр бүлдээ байх сонирхолгүй, эсвэл эцэг эх нь гэр оронгүй, гар бүлдээ зөрчилд орсон учраас хараа хяналтгүй сэлгүүцэх амьдралд дассан байна. Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газраас хараа хяналтгүй хүүхдийн тоог бууруулах зорилгоор Нийслэлийн Цагдаагийн газар, Хүүхдийн халамж үйлчилгээний болон иргэний нийгмийн байгууллагатай хамтран жил бүр илрүүлсэн (2011 онд 157, 2012 онд 65, 2013 онд 57) хараа хяналтгүй хүүхдийг нэгбүрчлэн хаягийг тодруулах, хөгжлийн хэрэгцээг үнэлэх, эрүүл мэндийн үзлэгт хамруулах, боломжтой бол гэр бүлийн гишүүдэд хүлээлгэн өгөх, гэр бүлтэйгээ эргэн нэгдэх боломжгүйг нь халамж асрамжийн газар түр шилжүүлэх зэргээр шаардлагатай үйлчилгээ үзүүлсэн байна. Энэ үйл ажиллагаанд халамжийн үйлчилгээний 11 төв гэрээ байгуулан ажиллаж, хүүхэд бүрт тулж нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлж байна.

150. 1997 оноос 2013 оны 7 сар хүртэл хугацаанд гэр бүлээсээ дайжин гудамжид гарсан хүүхдийг “Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай” хуулийн дагуу цагдаагийн байгууллагын дэмжлэгээр Хаяг тогтоох байранд хүлээн авч, шаардлагатай үйлчилгээг үзүүлж, улмаар халамж, асрамжийн төвд шилжүүлэн асран хамгаалж байсан юм. Хараа хяналтгүй хүүхдийг түр хамгаалах тухай хуулийг 2013 онд цуцалснаар Нийслэлийн Цагдаагийн газрын харьяанд ажиллаж байсан “Хүүхэд хамгаалал, хаяг тогтоох төв”-ийг татан буулгаж, цагдаагийн байгууллагын гүйцэтгэж байсан дээрх чиг үүрэг дүүргийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Нийслэлийн ХГБХГ ба ХТҮГ–г шилжсэн байна.

### **Сүм хийдэд шавилан сууж байгаа хүүхэд**

151. Буддын шашин нь Монголд олон зууны турш зонхилох шашин байсаар ирсэн. Ирээдүйд лам болох хүүхэд нь бага наснаасаа сүм хийдэд шавилан сууж, шавь орсон багшийн удирдлага зааврын дор Буддын шашны сургаал ном, ёс жаягт суралцдаг байсан. Энэ уламжлал 1990–ээд оноос сэргэж эхэлсэн. 1990–ээд онд хэдэн хүүхэд сүм хийдэд шавилан сууж байсан талаар мэдээлэл байхгүй байна. Харин ХЭҮК–ийн судалгаагаар 2002 онд шашны сургууль, дацанд 1248 хүүхэд суралцаж байснаас 8 хүртэл насны хүүхэд 29 байсан бол эдгээр тоо 2006 он хүртэл өсөж, нийт хүүхдийн тоо 6522, 8–аас доош настай хүүхдийн тоо 284 болжээ. Харин 2006 оны 7 дугаар сарын 1–ээс эхэлж

хэрэгжүүлсэн Хүүхдийн мөнгө хөтөлбөрт ерөнхий боловсролын сургуульд хамрагдаагүй, гэр бүлтэйгээ хамт амьдраагүй хүүхдийг хамруулахгүй гэсэн шалгуур үзүүлэлт тавьсны дагуу 2007 оны статистикийн бүртгэлээр дацан хийдэд шавилан суусан нийт хүүхдийн тоо 2251, 8-аас доош настай хүүхдийн тоо 25 болж буурсан байна. 2011 онд нийт хүүхдийн тоо 1362, 8-аас доош насны хүүхдийн тоо 15 болсноос үзэхэд шашны сургууль, дацанд суралцагч хүүхдийн тоо цөөрчээ.

152. 2014 онд ХТҮГ орон нутгийн байгууллагууд хамтран, “Сүм, хийдэд шавилан суудаг болон сүмийн үйл ажиллагаанд хамрагддаг хүүхдийн нөхцөл байдал” судалгаанд 21 аймаг, Улаанбаатар хотын 3 дүүргийн сүм хийдийн төлөөлөл болгон Будда, Христ, Исламын шашны сүмийн үйл ажиллагаанд хамрагддаг 2282 хүүхдийг судалсан байна. Тэднээс буддын шашны хийдэд тогтмол шавилан суудаг 502 хүүхэд байсан бөгөөд 1780 хүүхэд бусад шашны сүмд хүссэн үедээ ирж, үйл ажиллагаанд нь тогтмол хамрагддаг гэсэн тоо баримт гарсан байна.

153. Сүм хийдэд хүүхдэд зориулсан журам, ялангуяа хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар нэгдсэн журам, зохицуулалт байхгүй учир лам багш, ажилтнуудын хувьд хүмүүжлийн эерэг арга, хандлагын талаар мэдлэг дутмаг байгааг дээрх судалгаагаар тогтоожээ. Шашны байгууллага зөвхөн шашны ном заахыг урьтал болгодог шалтгаалан тэнд шавилан сууж байгаа хүүхэд орчин цагийн шаардлагад нийцсэн боловсрол эзэмшиж чадахгүйн дээр тэдний зарим эрх зөрчигдөхөд хүрч байна. Сүм хийдэд шавилан суугаад суурь боловсрол давхар эзэмших боломжгүй нь нэгэнт тодорхой байгаа учраас шашны сургалттай ерөнхий боловсролын сургуулийг үндэсний хэмжээнд бүслэн байгуулах шаардлагатай байна гэсэн ХЭҮК-ийн зөвлөмж гарсан байна.

### **Хүүхдийн хөдөлмөр**

154. Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгааны 2011–2012 оны тайланд 5–17 насны нийт хүүхдийн 15,9 хувь эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба тэдний 54,1 хувь хөвгүүд, 45,9 хувь охид байна. Эдгээр хүүхдийг насны бүлгээр авч үзвэл 5–9 насныхан 18,8 хувь, 10–11 насныхан 14,5 хувь, 12–14 насныхан 30,8 хувь, 15–17 насныхан 35,9 хувийг эзлэж байна. Ажил эрхэлж байгаа хүүхдийн 0,7 хувь өрхийнхөө орлогыг дангаар бүрдүүлдэг байна.

155. Ажил эрхэлж байгаа арван хүүхдийн найм нь хөдөө аж ахуйн салбарт, нэг нь бөөний болон жижиглэн худалдаа, засвар үйлчилгээний газарт ажиллаж байна. Мөн 15–17 насныхан уул уурхай, олборлолт, боловсруулах үйлдвэрт ажиллаж байна. Судалгааны тархаалтын тооцоогоор 5–17 насны 1857 хүүхэд өрхөөс гадуур эдийн засгийн ажиллагаа эрхэлж байх бөгөөд тэдний 65,4 хувь нь сургуульд сурдаг байв. Ажил эрхэлдэг нийт хүүхдийн 2,0 хувь цалин хөлстэй ажил эрхэлж байна. Эдгээр хүүхдийн 11,1 хувь хүнд хортой болон аюултай ажил хийж байна.

156. Засгийн Газар 2011 онд Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хүнд хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөрийг баталсан нь зохих үүрэг гүйцэтгэж байна. Хөтөлбөрийн үндсэн зорилгыг 2016 он гэхэд хүүхдийн хөдөлмөрийг тэвчишгүй хэлбэрийг бүрэн устгах гэж тодорхойлоод хүүхдийн хөдөлмөрийг зохицуулах хууль тогтоомжийг нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцийн зарчимд нийцүүлэх, энэ чиглэлээр хууль сахиулах

чадамжийг сайжруулах, хөдөлмөр эрхэлж байгаа, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт өртсөн хүүхдүүдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилтуудыг дэвшүүлжээ. Уг хөтөлбөрийг 2012 он хүртэл НХХЯ хэрэгжүүлж байсан бөгөөд мөн оны 7 дугаар сард Засгийн Газрын шинэ бүтцийн дагуу Хөдөлмөрийн яам шинээр байгуулагдсанаар хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг уг яам хариуцан ажиллаж байна. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарыг 15 нас болгохоор тусгасан.

157. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын тушаалаар 2009 онд Хүүхдийн хөдөлмөрт хийх хяналт шалгалтын аргачлал боловсруулж түгээсэн байна. Аргачлалын дагуу хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч нь аж ахуй, нэгж байгууллагуудад 2012 онд хийсэн шалгалтаар 1012 хүүхэд хөдөлмөр эрхэлж байгааг тогтоож, хууль журмын дагуу зохих арга хэмжээ авсан байна. Хүүхдүүд барилгын туслах ажил, уур уурхайн чиглэлээр ашигт малтмал олборлоход хүдэр шороо зөөх, хөнгөн хүнсний салбарт бараа материал зөөх ажил ихэвчлэн хийж байгааг уг шалгалтын тайланд дурджээ.

158. Хүүхдийн хөдөлмөрийн чиглэлээр нийслэл хотод 4 төрийн бус байгууллага хүүхдийг хүнд хөдөлмөрөөс хөндийрүүлэх, амралт, чөлөөт цагаа хамт олны дунд өнгөрүүлэх, нийгэмших, хөгжих боломжоор хангахад хязгаармагдмал нөөцийн хүрээнд ажиллаж байна.

159. Тайлант хугацаанд Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ILO/IPEC)-аас энэ чиглэлээр тусламж, дэмжлэгийг үргэлжлүүлэх асуудал шийдвэрлэгдээгүй. Учир нь Монгол Улсыг дунд орлоготой орны жагсаалтад шилжсэн гэж АЙПЕК хөтөлбөрөө 2011 онд дуусгасантай холбоотой юм.

### **Уралдаанч хүүхэд**

160. Уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангах талаар нөлөөллийн олон талын арга хэмжээ авч байна. Уралдаанч хүүхдийн бүртгэлийн систем бий болж, уралдаан бүрийг түүнд оролцох хүүхэд бүрийн аюулгүй байдлыг хянах мэдээллийн нэгдсэн сан бий болгосон. ([www; \http; unaach.nac.gov.mn](http://unaach.nac.gov.mn)) Уралдаанч хүүхдийн амьдрах нөхцөл, сурах боломжийг сайжруулах, эдгээр хүүхдийг хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт өртөх, эдийн засгийн мөлжлөгт орохоос нь сэргийлэх, хүүхдийн дээд эрх ашгийг хамгаалах асуудлаар хамтран ажиллахаар 30 шахам тал Санамж бичигт гарын үсэг зурж төв, орон нутгийн түвшинд ажиллаж байна.

161. Уралдаанч хүүхдэд хамгаалалтын хувцас, хэрэглэл хэрэглэж сургах нь чухал байна. 2013 онд уралдаанд оролцсон 4–15 насны хүүхдийн 52 хувь нь малгай, 37 хувь нь нүдний шил, 41 хувь нь хантааз, 41 хувь нь өвдгөвч, 52 хувь нь гутал өмссөн байна. Нэгтгэн дүгнэж үзвэл уралдаанч хүүхдийн 74 хувь ямар нэг төрлийн хамгаалалтын хувцас, хэрэглэл өмссөн, 22 хувь нь дээр дурдсан 5 төрлийн хамгаалалтын хувцас хэрэглэлийг бүгдийг нь өмсжээ. Гэсэн хэдий ч 4 хүүхэд тутмын нэг нь (26 хувь) хурдан морины уралдаанд орохдоо ямар ч хамгаалалтын хувцас өмсөөгүй гэсэн судалгааны дүн байна. Хамгаалалтын хувцас, хэрэгслийг зөвхөн уралдааны үед өмсөх хандлага байна. Түүнийг цаашид уралдааны бэлтгэл сунгаа, үсэргээ, тарлах үед ч өмсүүлж хэвшүүлэх шаардлага байна.

162. Монгол орны зун, намар буюу урин дулаан цагийн уралдаанд хүүхэд оролцохыг хориглох боломж тун бага, харин өвөл, хавар болох уралдаанч хүүхдэд эрсдэл өндөр тул

түүнд 16 хүртэл насны хүүхэд оролцуулахыг хориглох байр суурийг хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагууд барьж байна. Морин уралдаан жилийн аль ч улиралд болж, түүнд уралдаанч хүүхэд тогтмол оролцох хэлбэр нь хүүхдийн боловсролын хамрагдалтад нөлөөлж болзошгүй байна. ХТҮГ, орон нутгийн хүүхдийн байгууллагын бүртгэл мэдээллээс харахад жилд дунджаар 10 мянган хүүхэд зуны амралтаар морь унаж, уралдаанд оролцдог бөгөөд уралдаанд оролцогчдын 0.04 хувь нь хүнд, хүндэвтэр гэмтэж, зохих үйлчилгээ авсан байна. Хурдан морины уралдаанч хүүхдээс авсан асуулгаас харахад тэдний 50 хувь нь 7–9 насандаа, 31 хувь нь 7 нас хүрэхээсээ өмнө, 20 хувь нь 10 ба түүнээс хойш насанд хурдан морь унажээ. Хурдан морь унаж эхэлсэн дундаж нас 8 байна.

163. ҮСХ–ны 2014 оны Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаанд уралдаанч хүүхдийн талаар бүлэг асуулт оруулж, дүнг гаргахад улсын хэмжээнд 4–15 насны нийт хүүхдийн 5 хувь нь 2012 оны 11 сараас нэг жил хүртэл хугацаанд хурдан морь унасан байна. 4–15 насны хөвгүүдийн 10, охидын 1 хувь нь хурдан морь унасан унажээ. Уралдаанч хүүхдийн дийлэнх нь амьжиргааны түвшин доогуур айлын хүүхэд байдаг. Эхчүүдийн боловсролын түвшин, өрхийн амьжиргааны түвшин дээшлэх тусам хүүхэд хурдан морь унах нь буурах хандлагатай байсан ба хурдан морины хүүхдийн тал хувь нь хамгийн сүүлийн уралдаанд орохдоо морио зайдан унасан байна. Мөн 3 хувь нь сүүлийн уралдааны үеэр ямар нэгэн осол, гэмтэлд өртжээ. Морио зайдан унах нь 10–15 насны хүүхдийн дунд элбэг (60), баруун бүсэд (70), хөдөөд (52) хувь байна. Хамгийн сүүлийн уралдааны үеэр осол гэмтэлд өртсөн хүүхдийн хувь хангайн бүсийн аймагт 5, сумын төвийн хүүхэд 7, боловсролгүй эхийн 6 хүүхэд дунджаас доогуур орлоготой өрхийн хүүхэд 5 хувь зэргээр бусад хүүхэдтэй харьцуулахад бага зэрэг өндөр байна.

164. Хурдан морь унаач хүүхдийн нийгмийн хамгааллын асуудлын нэг хэсэг нь ослын даатгал болон морины эзэнтэй хийх гэрээ, урамшуулал юм. Хамгийн сүүлийн хурдан морины уралдаан оролцохдоо хурдан морь унаач хүүхдийн 59 хувь нь даатгал хийлгэсэн, 8 хувь нь гэрээ байгуулсан, 37 хувь нь урамшуулал авсан, харин 26 хувь нь ямар ч даатгал, гэрээ, урамшуулалгүй байсан байна.

**Зэвсэгт мөргөлдөөнөөс хүүхдийг хамгаалах, тэдний бие бялдар, сэтгэл зүйг эргээх, нийгэмшүүлэх талаар авч байгаа арга хэмжээ**

165. Монгол цэргүүд энхийг дэмжих ажиллагаанд оролцдог. 2009–2013 онд үүрэг гүйцэтгэсэн нийт 48 цэргийн багийн 7207 цэргийн алба хаагчдад ажиллагааны өмнөх бэлтгэл сургалтын явцад хүүхдийг цэрэг, зэвсэгт ажиллагаанд хамруулахгүй байх, очсон орондоо хүүхэд–цэрэгтэй зөв харьцах сэдвээр хичээл сургууль, дадлагын ажлыг Батлан хамгаалах яам тогтмол зохион байгуулжээ.

166. Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2–т 18–25 насны иргэн эрэгтэйчүүдийг цэргийн жинхэнэ албанд татна гэж заасан байдаг. Уг хуулийн 17 дугаар зүйлийн 1–д заасны дагуу цэргийн сургуульд 17 нас хүрсэн Монгол Улсын иргэнийг сонсогчоор элсүүлэн суралцуулж болно гэж хууль заасан ба уг хуулийн 3.1.8–р заалтад “Цэргийн сургуулийн сурагч” гэж цэргийн хөгжмийн сургууль болон цэргийн сургуулийн тусгай зөвшөөрөл бүхий бага, дунд боловсролын сургуульд суралцагчийг” хэлнэ гэж тодорхойлсон.

167. Батлан хамгаалахын Сайдын 2010 оны 79 тоот тушаалын БХИС–ийн материаллаг баазыг түшиглэн, “Тэмүжин Өрлөг” бүрэн дунд сургуулийг байгуулсан. “Тэмүжин Өрлөг” бүрэн дунд сургууль нь 7 дугаар ангид элсэн орох эрэгтэй хүүхдээс математик, монгол хэлний шалгалт авч элсүүлэн, 12 жилийн сургалтын стандартыг ханган, бүрэн дунд боловсрол олгохоос гадна математик, гадаад хэлний гүнзгийрүүлсэн, цэргийн анхан шатны сургалтыг явуулдаг. 2013–2014 оны хичээлийн жилд 205 сурагч сурч байна. Энэ сургуульд захирал, цэргийн албаны дарга, сургалтын менежер, нийгмийн ажилтан, мэргэжлийн багш, цэргийн хэргийн багш, номын санч, санхүүгийн албаны ажилтан зэрэг 25 хүний бүрэлдэхүүн ажилладаг.

168. Цэргийн хөгжмийн сургууль нь 1991 онд Батлан хамгаалахын Сайдын тушаалаар цэргийн хөгжимчин бэлтгэх Байнгын дамжаа нэртэй байгуулагдан, Цэргийн хөгжмийн сургууль болтлоо 21 жил сургалтын үйл ажиллагаа явуулж, 20 удаагийн төгсөлт хийсэн. 2013–2014 оны хичээлийн жилд нийт 90 сонсогч, сурагч байгаагийн 13 нь “Цэргийн хөгжмийн удирдаач” мэргэжлээр, 77 нь “Үлээвэр хөгжимчин” мэргэжлээр суралцаж байна. Цэргийн хөгжлийн сургуульд есдүгээр анги төгссөн /14–16 настай/, суурь боловсролтой хөвгүүдийг зохих журмын дагуу элсүүлж, дөрвөн жил сургах ба Хөдөлмөрийн яамнаас баталсан ажил хөдөлмөрийн индексээр “Үлээвэр хөгжимчин” мэргэжлээр техникийн боловсрол олгох сургалтыг үнэ төлбөргүй явуулдаг. Сургалтын эхний жил суралцагчид цэргийн байранд байрлах ба өдөрт дөрвөн удаа халуун хоол, цайтай. Суралцах хугацаандаа цэргийн дүрэмт хувцсаар үнэ төлбөргүй хангагддаг. Цэргийн хөгжмийн сургуулийн захиргаа, цэргийн алба, анги удирдсан багшийн зүгээс суралцагчдын эцэг, эхтэй улиралд 1, хичээлийн жилд 2 удаа нэгдсэн уулзалт, хурал зохион байгуулдаг ба шаардлагатай тохиолдолд суралцагчдын эцэг эхийг дуудаж уулзах ажлыг тогтмол явуулдаг байна.

#### **Бэлгийн мөлжлөг болон хүчирхийлэл**

169. Монголд эмэгтэйчүүдийг БНХАУ, Макао, Гонконг, БНСУ, Сингапур, Тайван, Турк, Израйл, Япон, Малайз болон Европын Холбооны Улсуудад худалдсан хэрэг бүртгэгдэх болсноор хүний наймааны илгээгч улс орон болж байна гэж ЦЕГ үзэж байна. 2009–2013 онд 113 хохирогчтой хүний наймаатай холбоотой 94 хэрэг бүртгэсэн. Үүнээс 54 хэргийн хохирогч БНХАУ–ын Эрээн, Хөх хот, Макао, Хайнан зэрэг газарт, Солонгос, Сингапур, Энэтхэг, Египет, Африк зэрэг улсад худалдагдсан, тэдгээрийн 41 нь 16–17 насны хүүхэд байсан юм. Харин үлдсэн 40 хэргийн хохирогч нь дотооддоо буюу эх орондоо хүний наймааны хохирогч болсон байна.

170. 2013 онд хүн худалдаалах 12 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, прокурор хяналт тавьж ажилласнаас хүүхэд хохирогчоор тогтоогдсон нэг хэрэг байна. 11 настай хүүхдийг хулгайлж, хөдөө гэртээ аваачин, жил гаруй хугацаанд мал маллуулсан үйлдэлд Нийслэлийн прокурорын газар яллах дүгнэлт үйлдэж хэргийг шүүхээр шийдвэрлүүлжээ.

171. 2010–2014 онд бэлгийн мөлжлөг, хүүхдийг хил дамнуулах худалдаалах асуудлаар 8 төрлийн судалгаа хийж, үр дүнг нь холбогдох байгууллага олон нийтэд мэдээлсэн байна. Тухайлбал, 2010 онд Үндэсний статистикийн хороо ОУХБ хамтран хийсэн “Биеэ үнэлэгч болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн судалгаа”–аар Нийслэлд 4683 биеэ үнэлэгч



байгаа, тэдний 0.9 хувь буюу 43 нь 15–17 настай, хамгийн бага нь 13 настай байна гэжээ. Хүний аюулгүй байдлын судалгааны төв, Хүүхдийн эрхийн үндэсний төв ТББ–ууд хамтран хийсэн “Өсвөр насны хүүхдийн садар самуун, бэлгийн мөлжлөгт өртөж буй талаарх судалгаа”–аар асуулгад оролцогчдын 89 хувь нь хүний наймааг “Ноцтой асуудал” хэмээн тодорхойлсон байна. Хүний наймааны төрөл, хэлбэрийн хувьд бэлгийн мөлжлөг болон хуурамч гэрлэлтийг хамгийн түгээмэл хэлбэр гэж үзсэн байна. Асуулгад оролцогчдын 41,6 хувь нь 20–24 насны, 34,7 хувь нь 15–19 насныхан буюу залуу, өсвөр насны хүүхэд ихэвчлэн хүний наймааны гэмт хэрэгт өртөж байна гэж үзсэн байна.

172. Цөөн тооны хүүхэд уран нугаралтын үзүүлбэрээр хилийн чанадад гэрээгээр ажиллах явцдаа хөдөлмөрийн мөлжлөг, хүний наймаанд өртөх эрсдэлтэй байдалд орсон үед гадаад дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газрууд, Эрүүгийн цагдаагийн газар хамтран ажиллаж, хүүхдийг эх оронд нь буцаасан байна.

173. 2011 он хүртэл хэрэгжүүлсэн “Хүн худалдаалах, хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр”–ийн хэрэгжилтэд НХХЯ ТББ–уудтай хамтран мониторинг хийсэн. Үнэлгээний дүнг үндэслэн, 2011 оноос Нийгмийн хамгаалал, Хөдөлмөрийн яам /одоо: Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам/ ЭКПАТ Монгол Үндэсний сүлжээтэй хүн худалдаалах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажилласан байна.

174. Энэ төрлийн хэргийг илрүүлэх, мөрдөх, буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх механизмыг бэхжүүлэхээр Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (ХХТТХ)–ийг 2011 онд батлуулсан юм. Энэ хуулийн 30 орчим заалт нь хохирогчийг хамгаалах, 11 заалт нь хүүхэд, тэр дундаа охидыг бэлгийн мөлжлөгт өртөхөөс сэргийлэх, хамгаалахтай холбоотой байна. Хууль батлагдсанаар хүн худалдаалахтай тэмцэх ажлыг уялдуулан зохицуулах бүтэц бүхий Дэд зөвлөл Хууль зүйн яаман дээр 2012 оны сүүлээс ажиллаж эхэллээ.

175. Садар самуунтай тэмцэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахдаа хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг ХЭК ийн Нэмэлт Протоколын 2, 3 дугаар зүйлд заасан харилцааг нарийвчлан тусгахаар судалж байна.

176. Харилцаа холбооны зохицуулах хороо, Оюуны өмчийн газар, ЦЕГ, ШӨХТГ–ууд хамтарч зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг хамгаалах хууль, Садар самуунтай тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Эрүүгийн хууль, Өрсөлдөөний тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль болон Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенциудыг зөрчсөн нийт 166 вэб сайтыг энэ оны 9 дүгээр сараас хаажээ.

177. Эрүүгийн хуулийн 113–р зүйлээр хүний наймааны бүх хэлбэрийг хориглосон бөгөөд ХХТТХ хууль батлагдсанаар энэ заалтад бусдын биеийг хүчээр үнэлүүлэх болон хүүхдийн биеийг үнэлэх асуудлыг нэмж хамааруулах боломжтой болсон.

178. Тахарын албаны тухай болон Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулиуд 2013 оны 07 дугаар сарын 05–ны өдөр батлагдаж 2014 оны нэгдүгээр сарын 1–ээс мөрдөж

байна. Энэ хуулийн 13 дугаар зүйлд “насанд хүрээгүй гэрч, хохирогчийг түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, эсхүл хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын зөвшөөрснөөр аюулгүй байдал хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулна” гэсэн заалтыг оруулсан нь бэлгийн мөлжлөг, хүний наймааны хохирогч болсон хүүхдийг хамгаалахад нөлөөлөх юм. Одоо гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангасан орчин бүрдүүлж, төсөв санхүү, дүрэм журмыг боловсруулж байна. 2014 онд байгуулагдсан Тахарын албаны дэргэд Гэрч хохирогчийг хамгаалах газар байгуулагдаж, энэ төрлийн гэмт хэргийн гэрч, хохирогчийг эрүүгийн хэргийн шүүн таслах үйл явцын шат бүрийн хамгаалалтад байлгах нөхцөлийг хангаж ажиллахыг зорьж, зохих талуудтай хамтран Гэрч хохирогчийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулж эхэллээ.

179. Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2009 оны А/14 тоот тушаалаар баталсан “Хүүхэд, эрх зүйн чадамжгүй хүнийг улсын хилээр нэвтрүүлэх журам”-ыг нарийвчлан 7-оос доош насны хүүхдийг зөвхөн эцэг, эх буюу хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамт улсын хилээр нэвтрүүлэх болов.

180. 2012 онд шинэчлэн найруулсан Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу хүчирхийлэлд өртсөн иргэнд халамжийн үйлчилгээ үзүүлж байна. Гэр бүлийн тухай хууль 25.5 болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон бие махбодын хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа 360 иргэнд 167,8 сая төгрөгийн халамжийн тэтгэмж үзүүлсэн байна.

181. 2012 онд Засгийн Газрын тогтоолоор гадаадад гэмт хэргийн хохирогч болсон монгол иргэдэд тусламж үзүүлэх, нөхөн төлбөр олгох санг Гадаад яаман дээр байгуулсан бөгөөд түүний талаарх мэдээллийг нийтлэг цөм тайланд дурдсан болно.

182. Хил хамгаалах ерөнхий газар, Азийн сан, Хүний аюулгүй байдлын Судалгааны төв, Хүйсийн тэгш эрхийн төв, Хүний эрх, хөгжил төв, ЭКПАТ Монгол Үндэсний сүлжээ зэрэг байгууллагууд хүний наймаа, бэлгийн хүчирхийллийн талаар сургалт мэдээллийг өргөжүүлэх, хохирогчийг хамгаалах үйлчилгээг тогтворжуулахад хамтран ажилласан байна. Хүний аюулгүй байдлын судалгааны төв 2010 онд ЕБС-ийн хүний эрхийн хичээлийн хөтөлбөрт хүн худалдаалахаас урьдчилсан сэргийлэх талаарх сэдвийг оруулах зорилгоор орон даяар нийгмийн ухааны 670 гаруй багш нарт “Хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх нь” сургалтыг зохион байгуулж, гарын авлагаар хангажээ. Тус төв хүн худалдаалах гэмт хэргийн талаар урьдчилан сэргийлэх сургалтыг үндэсний хэмжээнд зохион байгуулж нийт 558 сургуулийг хамруулсан нь үндэсний хэмжээний бүх сургуулийн 76,6 хувь буюу 100,000 сурагчийг хамарсан байна. Хүний аюулгүй байдлын судалгааны төв хүний наймааны эсрэг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гурван төрлийн богино хэмжээний кино хийж үндэсний хэмжээний гурван телевизийн сувгаар олон нийтэд цацсан нь бэлгийн хүчирхийллийн хохирогч нарын талаарх гэр бүлийн гишүүд, олон нийтийн ойлголтыг дээшлүүлэхэд хувь нэмэр боллоо.

183. Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хэргийг илрүүлэх, мөрдөн байцаах, шүүх, яллах үйл ажиллагааг бэхжүүлэх, хохирогчид үзүүлэх тусламжийн үйлчилгээг хөгжүүлэхэд АНУ-ын Азийн сан, Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний

Байгууллага (IOM), Швейцарын хөгжлийн агентлаг, “Оюу толгой” компани зэрэг байгууллага, аж ахуйн нэгжүүд техник, санхүүгийн дэмжлэг үзүүлж ирлээ. “Оюу толгой” ХХК уул уурхайн бүс нутагт хүүхэд, гэр бүлийг хүний наймаанаас хамгаалах урьдчилан сэргийлэх төсөлд 2014 онд 40.000.000 төгрөг хуваарилсан байна

184. Гэмт хэргийн хохирогчдод бие махбод сэтгэл санааны хувьд нөхөн сэргээх, нийгэмшүүлэх, эх оронд нь ирүүлэх зэрэгт олон улсын хамтын ажиллагааг дэмжсэн алхмууд хэрэгжиж байна. Тухайлбал, 2010 онд Хүн худалдаалахтай тэмцэх асуудлаар хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн Газар, БНХАУ-ын Макаогийн Засаг захиргааны онцгой бүсийн Засгийн Газар хоорондын хэлэлцээрийг байгуулсан. 5 бүлэг, 20 зүйлтэй уг хэлэлцээр нь эмэгтэйчүүдээс гадна хүүхдийг худалдахаас урьдчилан сэргийлэх, хохирогч хүүхдийг хамгаалах, эх оронд нь буцаах, нийгэмшүүлэхтэй холбогдуулан арваад заалтыг тусгайлан оруулсан. Хэлэлцээрийн хэрэгжилтийг дүгнэх зорилгоор Хүний аюулгүй байдлын судалгааны төв (ХАБСТ) нь 2014 оны 6 дугаар сарын 5–7-нд Гадаад харилцааны яам, Тахарын ерөнхий газар, Гэмт хэрэгтэй тэмцэх газар болон тус төвийн төлөөллийг оролцуулсан ажлын уулзалтыг АНУ-ын Азийн сангийн дэмжлэгтэй зохион байгуулсан. Үүний үр дүнд хэлэлцээрийг хэрэгжүүлэх 2014–2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх тохиролцоонд хүрсэн байна.

185. 2011 оны Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссийн тайланд дурдсанаар тухайн үед 30 гаруй төрийн бус байгууллага, 12 хандивлагчийн тусламжтайгаар 1–5 жилийн хугацаатай 13 төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байжээ. Тэднээс 2 байгууллага нь хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээ, 5 байгууллага хуулийн зөвлөлгөө, 4 байгууллага сэтгэлзүйн зөвлөлгөө, 10 орчим байгууллага сургалт явуулах, чадавх бэхжүүлэх үйлчилгээ эрхэлж байна. 2014 оноос энэ чиглэлийн 17 төрийн бус байгууллага нэгдэн, “Хүний наймааны эсрэг ТББ-уудын сүлжээ”-г байгуулж хамтран ажиллаж эхэллээ.

186. Орон нутагт ч бэлгийн мөлжлөгт өртсөн, хүчирхийллийн хохирогч охидыг хамгаалж, тэднийг нөхөн сэргээх, эргэн нийгэмшүүлэх үйлчилгээг үзүүлж эхэлсэн байна. Тухайлбал, Говь-Алтай аймгийн ХЭК-ийн тайланд тус аймагт хүчирхийлэлд өртсөн хүүхэд эмэгтэйчүүдийг хамгаалах байр буюу “Нэг цэг”-ийн үйлчилгээ, “Хүүхэд, гэр бүлд зөвлөлгөө өгөх танхим” зэргийг ажиллуулж, холбогдох хууль, шүүхийн байгууллагатай хамтран ажиллаж байгаа ажээ. Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн 23 хүүхдэд нөхөн сэргээх, сэтгэл зүйн зөвлөлгөө, дэмжлэг үзүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үйлчилгээг 2008 оноос хойш Хамтарсан багаар үзүүлснийг мөн тайланд дурджээ. 2010 оноос Улаанбаатар хот болон Замын-Үүдэд хүний наймааны хохирогчийг хамгаалах хоёр байр байгуулж өнөөг хүртэл Хүйсийн тэгш эрхийн төв ТББ ажиллуулж байна. Энэ нь хэрэг бүрдүүлэх шатанд хохирогчдыг хамгаалах боломжийг өргөжүүлж байна. Хамгаалах байраар үйлчлүүлсэн 111 хохирогчийн дотор 4 хүүхэд байсан байна. Хүүхдийн тусламжийн утасны зөвлөгч операторуудыг бэлгийн мөлжлөгөөс сэргийлэх, хохирогчийг хамгаалах, зөвлөгөө өгөх арга барилд сургаж байна. 2013 онд 11–13 насны 23 охиныг садар самуунд уруу татсан хэрэгт яллагдагч 25 жилийн хорих ял авсан.

187. Байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох, тоо баримт цуглуулах байдлыг сайжруулах чиглэлээр өгсөн Хорооны зөвлөмжийг хэрэгжүүлэхэд ахиц гарлаа.

АНУ–ын Азийн сан, Хууль зүйн яам, Дэд зөвлөлтэй хамтран холбогдох Төрийн бүх шатны / ХАНХЯ, ХЗЯ, ЭМЯ, ЭЦГ, УМБГ, ИБМТ, Иргэний харъяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар гэх мэт/ байгууллагыг хамруулсан мэдээллийн сан бүрдүүлэх, дэмжих төслийг хэрэгжүүлж байна. Харин төрийн байгууллагууд энэ чиглэлийн үйл ажиллагааг төсвөөс дэмждэг ч тогтвортой үйлчилгээ үзүүлэхэд хүрэлцэхгүй байна.

188. Хил хамгаалах ерөнхий газрын мэдээллээр хүүхдийг хүний наймаанд өртөхөөс сэргийлэх, тэдний нэр төрийг хүндэтгэх талаар ойлголт өгөх сургалтад хилийн шалган нэвтрүүлэх, хууль сахиулах байгууллагын ажилтнуудаас 2009 онд 1300, 2010 онд 2150, 2011 онд 1832, 2012 онд 2900, 2013 онд 6450 ажилтан, албан хаагчдыг хамруулжээ.

### **Хууль зөрчсөн болон гэрч хохирогч хүүхэд**

189. Шадар сайдын 2012 оны 28 тоот тушаалаар “Хүүхдийн хууль зүйн хорооны нийтлэг журам”– ыг баталжээ. Нийслэлийн бүх дүүрэг болон аймгуудад Засаг даргаар ахлуулсан Хүүхдийн хууль зүйн хороо байгуулагдаад байна. Орон нутаг дахь “Хүүхдийн хууль хороо” нь гэмт хэрэгт холбогдсон хүүхдийг аль болохоор хорих ялаас чөлөөлөх, ял эдлэх хугацааг хойшлуулах нөхцөлийг судалж, холбогдох байгууллагад санал дүгнэлт гаргаж байна. Тухайлбал 2012–2013 онд ХТҮГ, орон нутгийн байгууллагууд 200 гаруй хүүхдэд ийм дүгнэлт гаргажээ.

190. Захиргааны хариуцлагын тухай хуульд зааснаар 16 нас хүрсэн этгээд уг хуульд заасан зөрчлийг гаргасан бол түүнд захиргааны хариуцлага хүлээлгэх зохицуулалтай. Энэ хуульд заасан захиргааны зөрчилд оногдуулах шийтгэлийн төрөл нь хүүхдэд тусгайлан оногдуулах сонголтгүй, тохиромжгүйгээс зөрчил гаргасан хүүхдэд оногдуулахгүй орхих, эсвэл баривчлах шийтгэл оногдуулах гэсэн хэлбэрээр хэрэгжиж байна. Баривчлах шийтгэл нь 30 хүртэл хоногийн хугацаанд хэрэгжих бөгөөд энэ хугацаанд зөрчил гаргасан хүүхдийн сурч боловсрох, хөгжих төлөвших, эрүүл мэндийн, аюулгүй байдлын, эцэг эх ар гэртэйгээ холбоотой байх, мэдээлэл авах зэрэг эрхийг хангах зохицуулалт байхгүй байна. Тухайлбал, Захиргааны зөрчил гаргасан 16–18 насны этгээдийн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг оролцуулдаггүй, зөрчил гаргасан тухай хуульд заасан хугацаанд эцэг эх, ар гэр, өмгөөлөгчид нь мэдэгддэггүй байдал байна.

191. УИХ 2013 онд баталсан Төлбөрийн чадваргүй яллагдагчид эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хууль нь 2014 оны нэгдүгээр сарын 1–ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн. Энэ хуулийн үйлчлэлд гэмт хэрэгт холбогдсон хүүхэд эрх зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах зохицуулалтыг оруулж өгсөн. Хууль зүйн сайд, Сангийн сайд нарын хамтарсан 2014 оны 01 сарын 20–ны өдрийн А/05/8 дугаар тушаалаар Хууль зүйн туслалцааны төвийн салбаруудын орон тоо, байршлыг баталсан. Хууль зүйн туслалцааны төв нь ажлын алба, 32 салбартайгаар улсын хэмжээнд Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймаг болон 3 суманд төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг явуулж байна. Одоогийн байдлаар төвд ажлын албаны 9 албан хаагч, 47 улсын өмгөөлөгч, 4 өмгөөлөгчийн туслах ажиллаж эхлээд байна. Хууль зүйн туслалцааны төвд 2014 оны 2–6 дугаар сард нийт 982 хэргийн 1046 холбогдогч үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ авахаар хандсан байна.

192. Насанд хүрээгүй хүмүүсийн үйлдсэн хэрэг сүүлийн гурван жилийн байдлаар 2010 онд 455 хэрэгт 907 хүүхэд, 2011 онд 590 хэрэгт 1163 хүүхэд, 2012 онд 1076 хэрэгт 673 хүүхэд тус тус бүртгэгдсэн нь нийлбэр дүнгээрээ нийт 2021 хэрэгт 2743 хүүхэд шалгагдсан байна. Гэмт хэрэг үйлдсэн хүүхдүүдийн насыг үзвэл:

- 15 хүртэл насны 771 хүүхэд гэмт хэрэг үйлдсэн буюу нийт гэмт хэрэг үйлдсэн хүүхдийн 28.1 хувийг;
- 16–17 насны 1972 хүүхэд гэмт хэрэг үйлдсэн буюу нийт гэмт хэрэг үйлдсэн хүүхдийн 71.9 хувийг тус тус эзэлж байна.

Сүүлийн гурван жилийн байдлаар нийт 263 хүнд буюу жилд дунджаар 87 хүнд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг авсан байна. Эдгээр нь насанд хүрээгүй гэмт хэрэг үйлдсэн хүүхдүүд бөгөөд энэ нь нийт ял шийтгэлийн 1.1 хувийг эзэлж байна. 2010 онд 68 хүнд буюу насанд хүрээгүй гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн 7.5 хувьд, 2011 онд 63 хүнд буюу насанд хүрээгүй гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн 5.4 хувьд, 2012 онд 132 хүнд буюу насанд хүрээгүй гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн 19.6 хувьд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан байна. Өөрөөр хэлбэл нэг жилд дунджаар насанд хүрээгүй гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн 10.8 хувьд буюу 87 хүнд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг авсан байна.

193. 2013 оноос хэрэгжиж эхэлсэн Шүүхийн багц хуульд бие даасан шүүх байгуулж болох зохицуулалт шинээр орсон. Иймээс Хүүхдийн тусгайлсан шүүх байгуулах хууль эрх зүйн боломж бүрдсэн гэж үзэж болно. Хүүхдийг баривчлах, цагдан хорих, хорих ял эдлүүлэх ажиллагаанд прокурор байнгын тасралтгүй хяналт тавин ажиллаж байна. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийн заалтыг ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 461 дүгээр анги болон аймгийн цагдан хорих байруудад бүрэн хэрэгжүүлж, зарим цагдан хорих байранд насанд хүрээгүй хүүхдийн өрөөг тусад нь гаргасан. 2014 оны гуравдугаар сарын 28-ны байдлаар 22 хүүхэд байна. 2014 оны долдугаар сарын байдлаар Хүүхдийн хорих ангид 14–18 насны 35 эрэгтэй хүүхэд ял эдэлж байв. Хорих ял авсан эмэгтэй хүүхдийн хувьд эмэгтэйчүүдийн хорих ангид хүүхдэд зориулсан өрөөнд насанд хүрэгчдээс тусдаа хоригддог.

194. Насанд хүрээгүйчүүдийн хорих ангийн дэргэд 2000 оноос хойш ажиллаж байсан хөдөлмөрийн төрөлжсөн сургалттай суурь боловсрол олгох тусгай сургуулийг 2013 оноос бүрэн дунд сургууль болгон өөрчилж, ял эдэлж байгаа хүүхэд боловсролоо үргэлжлүүлэн эзэмших эрх бүрэн хангагдах нөхцөлийг бүрдүүлсэн юм. Насанд хүрээгүй ялтанд суурь боловсрол олгохдоо шинээр ирсэн хүүхдийн боловсролын түвшинг тогтоон, ерөнхий эрдмийн сургалтыг бага, дунд, ахлах ангийн түвшинд эзэмшүүлэн, суурь болон бүрэн дунд гэрчилгээ олгодог боллоо. Хүүхдийн боловсролын гэрчилгээ дээрээ хорих ял эдэлж байсан гэсэн тэмдэглэгээ хийхгүй байгаа нь ирээдүйд учирч болзошгүй ялгаварлан гадуурхалтаас хамгаалахад чухал үүрэгтэй. Ял эдэлж байгаа хүүхдийг мэргэжлийн сургалтад хамруулж, сүүлийн арваад жилд 539 хүүхэд талх, нарийн боов, жижиг урлал, гар хивс, ноосон эдлэл, мужаан, барилгын засал чимэглэл, тогооч, өрөгч угсрагчийн мэргэжилд суралцан мэргэжлийн үнэмлэх сертификат авсан байна. Мэргэжлийн сургалтыг олон улсын болон бусад төрийн бус байгууллагуудын дэмжлэг тусалцаатай зохион байгуулдаг юм.

195. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд насанд хүрээгүйчүүдийн хорих ангийн дүрмийг Хууль зүйн сайд батлахаар заасан ч энэ газрын тусгайлсан дүрэм журам өнөөг хүртэл гараагүй байна. Тийм учир хүүхдийн хорих ангид насанд хүрэгчдийн хорих ангийн нэгэн адил нэг журмаар зохицуулж байгаа нь хүүхдэд тохирохгүй байна. ШШГЕГ, ангийн захиргаа энэ байдлыг судалж, саналаа нэгтгэн, Хүүхдийн хорих ангийн дүрмийн төслийг боловсруулан яамандаа өргөн барьсан байна. Энэхүү дотоод журмын төслийг Хүүхдийн Эрхийн тухай НҮБ-ын Конвенц болон Эрх чөлөө нь хязгаарлагдсан насанд хүрээгүй хүнийг хамгаалах тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын журам зэргийн зарчимд нийцсэн хэлбэрээр шуурхай баталгаажуулна гэж найдаж байна.

196. Прокурорын байгууллагаас хүүхдийн хэрэгт хяналт тавьдаг Прокуроруудыг тусгайлан томилон ажиллуулж байна. Хүүхдийн эрхийн тухай Конвенци болон хүүхдийн эрхтэй холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар Нийслэл, дүүргийн прокурорын газруудын холбогдох прокурорыг хамруулан, 2011 оны есдүгээр сард Хууль зүйн Үндэсний хүрээлэнтэй хамтран сургалт зохион байгуулж, цаашид сургагч багш болгох чиглэлийг тавьсан. Мөн 2011 онд орон нутгийн прокуроруудыг оролцуулан “Насанд хүрээгүй хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй гэмт хэрэг /бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөг/ “сэдэвт 4 удаагийн, 2 багц сургалтыг Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран зохион байгуулсан. Улсын Прокурорын ерөнхий газраас 2012 оны есдүгээр сард Орхон аймагт болсон “Хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд олон нийтийн үүсэл санаачлага” сэдэвт аяны хүрээнд Хүүхдийн төлөө Үндэсний газартай хамтран, аймгийн шүүх, прокурор, цагдаагийн газрын 55 ажилтныг оролцуулан, “Насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт явуулах байцаан шийтгэх ажиллагааны онцлог, хэрэгжүүлэх арга зам” сургалт явуулсан.

197. Хүүхдийн Хууль зүйн хороо тэнсэн харгалзсан, ял хойшилсон, хорихоос суллагдсан хүүхдэд зөвлөлгөө өгөх, олон нийтэд тустай үйл ажиллагаанд зохих байгууллагатай хамтран хамруулах зэргээр хүүхдийг нийгэмшүүлэхэд анхаарах үүрэгтэй нэгжүүд орон нутагт үүссэн байна. 2009 онд 113, 2010 онд 99, 2011 онд 134, 2012 онд 213, 2013 онд 152 хүүхэд, нийт 645 хүүхдэд шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан байна. Дорнод аймгийн болон Нийслэлийн ХГБХГ хэлтэс 2012 оноос хүүхдийн эрсдэлийн түвшин тогтоох програмыг бий болгон туршилтаар ажиглаж, програмын давуу талыг хамтран хөгжүүлж байна.

198. 2013 онд насанд хүрээгүй хүнд эрүү шүүлт тулгасан гэх 1 хэрэг бүртгэгдсэн бөгөөд насанд хүрээгүй 2 хүүхдэд хилс хэрэг хүлээлгэхийн тулд бие махбодын хүчирхийлэл хэрэглэж гэмтэл учруулсан Эрүүгийн цагдаагийн хоёр ажилтныг эрүү шүүлт тулгасан гэмт хэрэгт Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албанаас /энэ алба татан буугдсан болно/ 2013 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 251 дүгээр зүйлийн 251.1 дэх хэсэгт зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, Нийслэлийн прокурорын газраас яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлжээ.

#### **Хүүхдийн тусламжийн утас-108**

199. Хүүхдийн тусламжийн утасны үйлчилгээг шинэчлэх 3 жилийн төслийг хэрэгжүүлж эхлээд байна. Хүүхдийн тусламжийн утас-108 нь хүүхдийн мэдээлэл хайх,

олох, тусламж хүсэх, шаардах эрхийг хангах зорилготой, 24 цагийн үйлчилгээтэй бөгөөд хүүхэд, гэр бүлийн гишүүдийн хамтдаа аж төрөх халуун дулаан уур амьсгалыг дэмжих зөвлөлгөө мэдээлэл өгнө. Хүүхдийн эрхийн зөрчлийн тухай иргэд, байгууллагын мэдээллийг нарийвчлан бүртгэж, эрсдэлийн үнэлгээ хийнэ.

200. Хүлээн авч, бүртгэсэн яаралтай дуудлагыг тухайн хүүхдэд хамгийн ойр байгаа төрийн байгууллагын шаардлагатай хариу үйлчилгээнд холбоно. Хариу үйлчилгээнд холбосон хүүхдэд хамгааллын кейс бүрийг үйлчилгээний явц, чанар, байдлыг хянаж, зохих зөвлөлгөө, дэмжлэгээр хангах, хамтран ажиллах хэлбэрийг хэрэгжүүлнэ. Тусламжийн утасны үйлчилгээний энэ систем нь тусгайлан боловсруулсан программын дэмжлэгээр гүйцэтгэгддэг юм.

201. Тусламжийн утас ажилласан эхний 3 сард буюу сургууль, цэцэрлэгийн амралтын хугацаанд 7095 дуудлага хүлээн авснаас зорилтот буюу хүүхдийн эрхийн зөрчил, хүүхэд хамгааллын дуудлага 63,7 хувийг эзэлж байна. Дуудлага өгсөн мэдээллийн шалтгаан нь хүүхдийн эсрэг бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамттай холбоотой байна. Мөн хүүхдийн асрамж хамгаалалтай холбоотой эрх зүйн туслалцаа хүссэн дуудлага өндөр байна.

#### **Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, шуурхай тусламж**

202. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг орон нутгийн түвшинд үзүүлэхийг зорьж байна. Энэ зорилгоор Нийслэлийн бүх дүүрэгт байгуулсан Хүүхэд гэр бүлийн хөгжлийн төв, аймаг, нийслэлийн Хүүхэд гэр бүлийн хэлтэс, газар, ХТҮГ–т хүүхэд хамгааллын үйлчилгээ хариуцсан 1–5 ажилтан бүхий хүүхэд хамгааллын нэгж ажиллаж эхэллээ. Эдгээр нэгж нь Хүүхдийн утас 108 дээр ирсэн дуудлагын мөрөөр хариу үйлчилгээ үзүүлэх ажлыг хариуцаж байна.

203. Хүүхэд хамгааллын яаралтай тусламжийн үйлчилгээг Нийслэлд эмнэлэгт түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээ (НЦҮ)–ний гурван нэгж үзүүлж байна. Орон нутгийн хувьд Завхан, Говь–Алтай аймагт ийм нэг цэгийн үйлчилгээ байна. Эдгээр нь дан хүүхдэд бус гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн бүх хүнд үйлчлэх үүрэгтэй.

#### **Кейс менежмент/Холбон зуучлах үйлчилгээ**

204. Хүүхдийн утсанд болон Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэс, төвүүдэд шууд ирсэн хүүхэд хамгаалалтай холбоотой “халуун биш” дуудлага, мэдээллийн мөрөөр авдаг нэг арга хэмжээ нь холбон зуучлах үйлчилгээ юм. Хүүхдэд тулгарч байгаа эрсдэлийн түвшин, хэрэгцээнд үндэслэн, сум, хорооны нийгмийн ажилтанд мэдэгдэх, хууль, эрүүл мэнд, нийгмийн халамж, иргэний бүртгэл, боловсролын байгууллагын үйлчилгээний талаар эцэг эх, харгалзан дэмжигчдэд нь мэдээлэл өгөх зэргээр үйлчилгээ үзүүлж байна. Сум, хорооны нийгмийн ажилтанд нь мэдэгдэж, улмаар хамтарсан багаар үйлчилгээ үзүүлэхийг чухалчилж байна.

205. Илтгэлд холбоотой 2009–2013 оны статистик мэдээллийг хавсаргав.

## **6.7 ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ТАВДУГААР ТАЙЛАН, ИЛТГЭЛИЙГ ХЭЛЭЛЦЭЭД НҮБ-ЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХОРООНООС ӨГСӨН ЗӨВЛӨМЖ**

### **I. Оршил**

1. Хороо нь Монгол Улсын 5-р тайлан илтгэлийг (CRC/C/MNG/5) 2017 оны 5-р сарын 26-ний өдөр хуралдсан өөрийн 2210 болон 2211 дугаар уулзалтаар (баримт бичгийн бүртгэлийн дугаар-CRC/C/SR.2210 болон 2211) хэлэлцэж 2017 оны 6-р сарын 2-ны өдөр хуралдсан 2221 дүгээр хуралдаанаараа энэхүү ажиглалт зөвлөмжийг хэлэлцэж батлав.

2. Хороо нь тус улсыг 5 дугаар тайлангаа болон Тулгамдсан асуудлуудын лавлагаанд хариу болгож Монгол Улс дах хүүхдийн эрхийн нөхцөл байдлыг илүү сайн ойлгох боломж өгсөн хариултыг бичгээр ирүүлснийг (CRC/C/MNG/Q/5/Add.1) талархан хүлээж авсан билээ. Мөн тус улсаас олон салбарыг төлөөлсөн өндөр түвшний төлөөлөгчдийн баг ирж маш үр дүнтэй хэлэлцүүлэг яриа өрнүүлсэнд Хорооны зүгээс талархаж буйгаа илэрхийлье.

### **II. Тус улсаас хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ болон хүрсэн ололт амжилт**

3. Өмнөх тайлангаа хэлэлцүүлснээс хойших хугацаанд олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийг соёрхон батлах, нэгдэн орох зэргээр, тухайлбал, 2015 онд Мэдээлэл хүргэх журмын тухай нэмэлт протоколыг соёрхон баталсан болон хүүхдийн эрхтэй холбоотой байгууллагыг шинэчлэх, бодлогын шинэчлэл хийх, хэд хэдэн хууль тогтоомжийг шинээр батлах ажлуудыг хийсэн ололт амжилтыг Хороо үнэлж байна. Тухайлбал, Хүүхэд хамгааллын хуулийг шинээр баталсан, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хөдөлмөрийн хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль, Эрүүгийн хууль зэргийг шинэчлэн найруулсныг онцлон талархаж байна.

### **III. Тулгамдсан асуудлууд болон зөвлөмжүүд**

4. ХЭК-д тусгагдсан хүүхдийн бүх эрх өөр хоорондоо нягт уялдаатай, хуваагдашгүй цул гэдгийг болон энэхүү дүгнэлт зөвлөмжид багтаасан бүх зөвлөмж туйлын чухал гэдгийг Хорооны зүгээс тус улсад сануулж байна. Дараах чиглэлээр нэн даруй арга хэмжээ авах хэрэгтэй байна гэдэгт тус улсын анхаарлыг Хороо хандуулахыг хүсэж байна. Үүнд: төсөв нөөцийн хуваарилалт (9-р зүйл), бизнесийн салбар ба хүүхдийн эрх (14-р зүйл), үл ялгаварлах (16-р зүйл), гэр бүлийн орчин (26-р зүйл), орчны эрүүл мэнд (35-р зүйл), хүүхдийн хөдөлмөр болон унаач хүүхдийн асуудлыг багтаасан эдийн засгийн мөлжлөг (41-р зүйл).



## **А. Хэрэгжилтийн ерөнхий арга хэмжээнүүд (4, 42, 44 (6) зүйлүүд)**

### **Хууль тогтоомж**

5. 2016 оны 2 дугаар сард Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын хууль баталсныг Хорооны зүгээс сайшаан тэмдэглэхийн хамт эдгээр хуулийг ХЭК–д нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай бүх арга хэмжээг авахыг зөвлөж байна. Ялангуяа, шаардлагатай санхүү, арга зүй, хүний нөөцийг хангалттай хуваарилахад илүү анхаарна уу.

### **Цогц бодлого ба стратеги**

6. Урт хугацааны бодлого шийдвэрийг гаргаж хэрэгжүүлэх нь ерөнхийдөө бэрхшээлтэй гэдгийг тэмдэглэхийн зэрэгцээ ХЭК–ийн бүхий л чиглэлээр хүүхэдтэй холбоотой цогц бодлого баримтлахыг тэргүүлэх зорилтоо болгохыг Хороо тус улсад зөвлөж байна. Энэхүү цогц бодлогодоо суурилан үр дүнтэй хэрэгжүүлэх алсын хараа стратеги боловсруулах шаардлагатай юм. Боловсруулсан стратеги нь хангалттай санхүү, арга зүй, хүний нөөцөөр дэмжигдсэн байх нь зүйтэй.

### **Зохицуулалт**

7. Өмнө өгсөн зөвлөмжийн дагуу (CRC/C/MNG/CO/3–4, 12 дугаар зүйл), өмнө нь Хүүхдийн төлөө үндэсний газар нэртэй байгаад одоо Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар гэж шинээр нэрлэгдэх болсон байгууллагыг хүүхдийн эрхийн хэрэгжилтийг зохицуулах гол үүргээ амжилттай хэрэгжүүлэх боломжийг хангахуйц санхүү, арга зүй, хүний нөөцөөр хангах ажлыг яаралтай хийхийг тус улсад зөвлөж байна.

### **Нөөцийн хуваарилалт**

8. Тус улсын санхүүгийн хүндрэлтэй байдал болон төлөвлөлт, санхүүжилт, үр дүнгийн хоорондын холбоосыг сайжруулах зорилго бүхий хөтөлбөрт суурилсан санхүүгийн тогтолцоонд шилжиж байгааг тэмдэглэхийн зэрэгцээ хүүхдийн эрхийг хамгаалах, хангахад чиглэсэн нийгмийн суурь үйлчилгээнд тогтвортой хөрөнгө оруулалт дутагдаж байгаа, хээл хахууль, олборлох уул уурхайн салбараас хэт хамааралтай байдал, түүний огцом өсөлт уналт зэргээс болж улсынх нь эдийн засаг хямарсан зэргээс шалтгаалан хүүхдийн эрхийг хангах чиглэлээр өмнө олсон амжилтаасаа ухарсанд туйлын харамсаж байна.

9. Хүүхдийн эрхийг хангах чиглэлээр улсын төсөв ямар байх талаар өмнө өгсөн зөвлөмжөө сануулж (CRC/C/MNG/CO/3–4, өмнөх тайлангийн 18–р зүйл), 2016 онд Хорооноос гаргасан Хүүхдийн эрхийг хангах төсөвлөлтийн тухай 19–р ерөнхий зөвлөмжийн хүрээнд дараах арга хэмжээг нэн яаралтай хэрэгжүүлэхийг шаардаж байна. Үүнд:

- (а) ХЭК–ийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв хөрөнгийн хуваарилалт, хүртээмж, үр ашиг, тэгш байдлыг хэрхэн харгалзаж буй зэргийг нь үнэлэн дүгнэхэд шаардлагатай бүртгэл, тусгай шалгуур үзүүлэлтүүдийг хамруулсан, хүүхдийн эрхийн хандлагаар хийгдсэн, үр дүнд чиглэсэн буюу хөтөлбөрт суурилсан

- төсвийн менежментийн шинэчлэл хийх санаачилгаа улам бэхжүүлэх
- (b) Олон нийтийг, тухайлбал, хүүхдүүдийг төсвийн хэлэлцүүлэгт оролцуулах замаар болон төрийн албан хаагчдын хариуцлагыг нэмэгдүүлэх байдлаар төсвийн ил тод, оролцоот байдлыг хангах
  - (c) Нийгмийн хамгааллын арга хэмжээ шаардахаар хүнд болон эмзэг нөхцөл байдалд байгаа хүүхдүүдэд зориулсан төсвийн задаргааг тогтоож эдийн засгийн уналт, хямрал, байгалийн гамшиг болон бусад онцгой байдлын үед ч тэрхүү зориулалтын төсөв танагдахгүй байхад анхаарах;
  - (d) Үйлчилгээ үзүүлэхэд зориулан хуваарилсан төсвийг өөрчлөх танах болбол уг өөрчлөлт нь хүүхдийн эрхийг хэрэгжүүлж байгаа тухайн үеийн түвшнээс доошлохгүй байхад анхаарах;
  - (e) Бүх хэлбэрийн хээл хахуулийг ихээхэн хэмжээгээр бууруулна гэж тусгасан Тогтвортой хөгжлийн зорилтуудын 16.5 дах заалтыг сануулахын ялдамд хээл хахуулийг илрүүлэх, мөрдөн шалгах, ял шийтгэл ноогдуулах институцийн чадавхыг дээшлүүлж түүнтэй тэмцэх бүхий л хүчин чармайлтаа төрийн зүгээс идэвхжүүлэх.

### **Мэдээлэл цуглуулах**

10. ХЭК-ийн хэрэгжилтийн ерөнхий арга хэмжээний талаар Хорооноос гаргасан Ерөнхий зөвлөмж 5-ыг (2003) хэрэгжүүлэх талаар дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

- (a) Мэдээлэл цуглуулах тогтолцоогоо аль болохоор яаралтайгаар үр дүнтэйгээр сайжруулах. Бүх хүүхдийн нөхцөл байдал, нэн ялангуяа эмзэг байдлын нэн хүнд нөхцөлд байгаа хүүхдүүдийн талаар дүгнэлт шинжилгээг сайжруулахын тулд Конвенцийн бүх хүрээг хамруулан хүүхдийн нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, газарзүйн байршил, яс үндэс, нийгэм-эдийн засгийн байдал зэрэг задаргаагаар мэдээллийг цуглуулах;
- (b) Тухайн асуудлаар ажилладаг яамд мэдээллийн өгөгдөл болон шалгуур үзүүлэлтүүдийг нэгдсэн байдлаар ашигладаг, тэдгээрийг Конвенцийг үр дүнтэй хэрэгжүүлэх бодлого, шийдвэр, төсөл хөтөлбөрийг боловсруулах, хяналт, үнэлгээ хийхдээ ашигладаг байхад анхаарах;
- (c) Хүний эрхийн дээд комиссарын ажлын албанаас эрхлэн гаргасан Хүний эрхийн шалгуур үзүүлэлтүүд: Статистикийн мэдээллийг тогтоох, цуглуулах болон түгээн дэлгэрүүлэхдээ ашиглах хэмжилтийн аргууд болон хэрэгжилтийн гарын авлагад тусгагдсан арга зүй, онолын хүрээг хэрэглэх;
- (d) Энэ чиглэлийн арга зүйн тал дээр НҮБ-ын Хүүхдийн сан болон бусад байгууллагуудтай хамтын ажиллагаагаа бэхжүүлэх.

### **Бие даасан хяналт шинжилгээ мониторинг**

11. Өмнөх зөвлөмжөө эргэн сануулахын ялдамд (CRC/C/MNG/CO/3-4, 16-р зүйл) Хүний эрхийн бие даасан байгууллагын үүргийн талаар Ерөнхий зөвлөмж 2-т (2002) заасныг үндэслэн дараах зөвлөмжийг нэмж өгч байна. Үүнд:

- (a) Хүний эрхийг дээдлэх, хамгаалахын тулд үндэсний хэмжээний хүний эрхийн

- байгууллагын статусыг тогтоосон Парисын тунхаглалын зарчимд нийцүүлэн өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь хүрэлцэхүйц хэмжээний санхүү, арга зүй, хүний нөөцөөр Монгол Улсын Хүний эрхийн комиссыг хангах талаар анхаарах;
- (b) Сонгон шалгаруулах, томилгоо хийхдээ ойлгомжтой тодорхой, ил тод, оролцоот үйл явцыг бүрдүүлэхийн тулд 2014 оны 10 дугаар сард Дэлхийн хүний эрхийн байгууллагуудын эвслийн дэргэдэх магадлан итгэмжлэх дэд хорооны гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх
- (c) Унаач хүүхдийн эрх, гэр бүлийн хүчирхийлэл, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, бие махбодын шийтгэл, хүүхдэд асрамж халамжийн үйлчилгээ үзүүлэгчдэд мониторинг хийх, тэдний үйл ажиллагааг зохицуулах, төрсний гэрчилгээний олголт зэрэг асуудлаар Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссоос ирүүлсэн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх.

### **Түгээн дэлгэрүүлэх, ойлголт нэмэгдүүлэх болон сургалт**

12. Хороо өмнөх зөвлөмжөө дахин сануулахын (CRC/C/MNG/CO/3-4, para.22) зэрэгцээ дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

- (a) Конвенцийн бүхий л зүйл заалтуудыг олон нийт, эцэг эх, асран хамгаалагч, багш, нийгмийн ажилтан болон хүүхдийн төлөө болон хүүхэдтэй ажилладаг бүх мэргэжилтнүүд, мөн хүүхдүүд өөрсдөө сайн мэддэг байхад чиглэгдсэн, одоогоор хангалттай хийж чадахгүй байгаа ойлголт нэмэгдүүлэх хөтөлбөр, кампанит ажлуудаа сайжруулах;
- (b) Хууль сахиулах байгууллагад ажилладаг бүх ажилтнууд, багш нар, эрүүл мэндийн ажилтнууд, нийгмийн ажилтнууд, хүүхдийн асрамж халамжийн үйлчилгээ үзүүлдэг ажилтнууд, бүх шатны төрийн байгууллагын ажилтнуудыг Конвенцээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлэх чиглэлээр тогтмол сургалтад хамруулж байхад анхаарах.

### **Хүүхдийн эрх ба бизнесийн салбар**

13. Бизнесийн үйл ажиллагааны сөрөг нөлөөллийг багасгах чиглэлээр тус улсын авч явуулж буй арга хэмжээг Хорооны зүгээс сайшаахын ялдамд олборлох уул уурхайн салбар зэрэг бизнесийн байгууллагууд хүүхдэд үзүүлж буй сөрөг нөлөөгөө багасгахад чиглэсэн дүрэм журамгүй байгаад сэтгэл зовниж байна. УИХ-ын гишүүд, Засгийн газрын гишүүд гэх мэт төрийн албанд ажиллаж буй хүмүүс өөрсдөө морь уях, уралдуулах, эмийн болон архи тамхины үйлдвэрлэл эрхлэх зэргээр хувийн ашиг сонирхлоо нийтийн ашиг сонирхолтой зөрчилдүүлэн ажиллах явдал гарсаар буйд туйлын ихээр харамсаж байгаагаа илэрхийлье.

14. Хүүхдийн эрхийн хэрэгжилтэд бизнесийн салбарын нөлөөллийн талаар гаргасан Ерөнхий зөвлөмжийг үндэслэн (2013) олон улсын болон үндэсний хүний эрх, хөдөлмөр, байгаль орчин болон бусад стандартыг, ялангуяа хүүхдийн эрхтэй холбоотой зүйл заалтуудыг бизнесийн салбарынхнаар хатуу мөрдүүлэхэд чиглэсэн дүрэм журам гаргаж хэрэгжүүлэхийг Хорооны зүгээс тус улсад зөвлөж байна. Тухайлбал, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ үү. Үүнд:

- (a) Олборлох салбарыг зохицуулах хуулийг баталж энэ салбарын үйл ажиллагаа хүүхдэд сөрөг үр дагавар учруулахгүй байхад хэрэгжилтийг нь чиглүүлэх;
- (b) Төрийн албанд ажиллаж байгаа хүмүүс хувийн ашиг сонирхлоо нийтийн ашиг сонирхолтой зөрчилдүүлэх явдлыг арилгахын тулд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль гэх мэт хууль тогтоомжийг мөрдүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авах;
- (c) Хүний эрх болон бизнесийн талаарх НҮБ-ын үндсэн зарчмыг хэрэгжүүлэх үндэсний төлөвлөгөөг Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгийн (тайлан нь A/HRC/30/6, para.108.162 and A/HRC/30/6/Add.1 гэсэн нэрийн дор цахим санд бий) хүрээнд тус улсаас хүлээсэн үүргээ биелүүлэхтэй уялдуулан боловсруулж батлах;
- (d) 2013 оны 4-р сард гарсан Хүний эрх ба улс дамнасан корпорацууд болон бусад бизнесийн байгууллагын асуудлаар НҮБ-ын Ажлын хэсгээс гаргасан зөвлөмжийг (A/HRC/23/32/Add.1) хэрэгжүүлэх.

### **С. Ерөнхий зарчмууд (2, 3, 6 болон 12-р зүйлүүд)**

#### **Үл ялгаварлах**

15. Хорооны зүгээс тус улсад тэгш бус байдал өссөөр байгаад, ялангуяа орлого багатай өрхийн хүүхдүүд, шилжин суурьшсан болон бүртгэлгүй хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, үндэстний цөөнх болон өөр хэлтэй хүүхдүүд, уугуул иргэдийн хүүхдүүд, гей, лесбиян, трансжендер хүүхдүүд (LGBT) гэх мэт эмзэг, хүнд нөхцөлд орсон хүүхдүүдийг ялгаварлан гадуурхалтад өртүүлж буйд, тухайлбал энэ тохиолдлууд нь сургууль, дотуур байрны орчинд гараад байхад ямар ч хариуцлага тооцдоггүйд харамсаж байна.

16. Ялгаварлан гадуурхахыг хориглосон хууль тогтоомжоо мөрдүүлэх арга хэмжээг бэхжүүлэх замаар ийм ялгаварлан гадуурхалтад хүргэж байгаа хандлага, хэвшмэл буруу ойлголтыг арилгахад чиглэсэн дараах тодорхой арга ажлыг яаралтай хийхийг тус улсад зөвлөж байна. Үүнд:

- (a) Ялгаварлан гадуурхалтын талаар мэдээлэх явдлыг дэмжих
- (b) Ийм зөрчил гаргасан хүмүүст тохирох арга хэмжээг нь шуурхай ноогдуулахад анхаарах;
- (c) Хүүхдийн төлөө болон хүүхэдтэй ажилладаг багш, нийгмийн ажилтан, асрамж халамжийн газрын ажилтнууд, нутгийн захиргааны байгууллагын ажилтнууд гэх мэт мэргэжилтнүүд, эцэг эх, хүүхдэд чиглэсэн ойлголт дээшлүүлэх, боловсрол олгох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх.

#### **Хүүхдийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих**

17. Хүүхэд хамгааллын хууль болон бусад саяхан батлагдсан хууль тогтоомждоо хүүхдийн ашиг сонирхлыг дээдлэхийг нэн тэргүүнд анхаарах талаар оруулсанд талархахын зэрэгцээ Хороо өмнөх зөвлөмжөө (CRC/C/MNG/CO/3-4, para.28) дахин

сануулж байна. Мөн Хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавих тухай Ерөнхий зөвлөмж 14-ийн (2013) хүрээнд дараах зөвлөмжийг тус улсад өгч байна. Үүнд:

- (a) Гэр бүлийн хууль, хүүхдийн асран хамгаалагчийг тогтоох, эцэг эхэд ял шийтгэл ноогдуулах зэрэгтэй холбоотой шүүх, прокурор, захиргааны шийдвэр гаргах, тайлбар өгөх зэрэгтээ хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавихыг бүхий л үйл явцын туршид мөрддөг байхад анхаарах
- (b) Хүүхэдтэй хамаатай бүхий л асуудлаар хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд тогтоох үүрэг хүлээсэн бүх хүмүүст өгөх энэ чиглэлийн заавар зөвлөгөө, шалгуур журмыг боловсруулах;
- (c) Дээр дурдсан шалгуур журамд үндэслэн 24 цагийн цэцэрлэг, дотуур байр, асрамж, халамжийн газрын үзүүлж буй үйлчилгээ, бодлого, үйл ажиллагаа нь хүүхдийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих шаардлагад нийцэж байна гэдэгт үнэлэлт дүгнэлт хийх
- (d) Хүүхдийн төлөө болон хүүхэдтэй ажиллаж буй бүх мэргэжилтнүүд өөрсдийн ажил үүргийг гүйцэтгэх явцдаа хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьдаг байхад анхаарах.

#### **Хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх**

18. Өмнө өгсөн зөвлөмж (CRC/C/MNG/CO/3-4, para.32) болон Хүүхдийн дуу хоолойгоо илэрхийлэх эрхийн талаарх Ерөнхий зөвлөмж 12-ыг үндэслэн Хорооноос дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

- (a) Хүүхдийн оролцоог дэмжих стратеги болон Хүүхэд хамгааллын хуульд тусгагдсан хүүхэд өөрийн үзэл бодлыг илэрхийлэх боломжийг олгох, үзэл бодлыг нь тэдэнд нөлөөлж буй асуудлыг шийдэх явцад харгалзан үзэх заалтуудыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүү, арга зүй, хүний нөөцөөр хангах;
- (b) Нийгмийн ажилтнууд болон шүүх хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх зарчмыг мөрдөх тогтолцоог бүрдүүлэх замаар шүүн таслах үйл ажиллагаанд хүүхдийн дуу хоолойгоо илэрхийлэх эрхээ эдлэх боломжийг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарах;
- (c) Бүх хүүхдүүд, ялангуяа охид, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон LGBT хүүхдүүдийн дунд гэр бүл, орон нутаг, сургуулийнхаа үйл ажиллагаанд утга учиртай оролцох замаар чадваржих боломжийг нь өгч чадах хөтөлбөр, ойлголт нэмэгдүүлэх үйл ажиллагааг явуулах.

#### **Эсэн мэнд амьдрах, хөгжих эрх**

19. Тус улсын хэрэгжүүлсэн арга хэмжээг цохон тэмдэглэхийн зэрэгцээ осол гэмтэл, ялангуяа 5-аас доош насны хүүхдүүдийн түлэгдэлт, хөдөө орон нутагт автозамын хөдөлгөөн ихэссэнээс нэмэгдсэн осол аваар, морин уралдааны улмаас гарч буй гэмтэл осол зэрэг нь хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих эрхэнд эрсдэл учруулж буйд Хороо тун ихээр сэтгэл зовниж байна. Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх талаар эцэг эх олон нийтэд сургалт сурталчилгаа хийх, буруутай этгээдэд хариуцлага тооцох гэх мэтээр осол

гэмтлээс урьдчилан сэргийлэх хүчин чармайлтаа бэхжүүлэхийг Хорооны зүгээс тус улсад зөвлөж байна.

#### **D. Иргэний эрх, эрх чөлөө (7, 8, болон 13–17 дугаар зүйлүүд)**

##### **Төрсний гэрчилгээ болон үндэс угсаа**

20. Төрсний гэрчилгээ авсан хүүхдийн хувь өндөр байгааг тус улсын тайланд дурдсаныг онцлон тэмдэглэхийн зэрэгцээ хүн бүрд төрсний гэрчилгээ, иргэний бичиг баримт олгох талаар заасан Тогтвортой хөгжлийн зорилтуудын 16.9-т анхаарлаа хандуулахыг Хорооны зүгээс сануулж дараах зөвлөмжийг өгч байна:

- (a) Казах хүүхдүүд, улсынхаа нутаг дэвсгэр дээр шилжин суурьшсан хүүхдүүд, эх баригчийн дэмжлэггүй гэртээ төрсөн хүүхэд зэргийг оруулаад бүх хүүхдэд төрсний гэрчилгээ олгох замаар иргэний бичиг баримттай болгох хүчин чармайлтаа бэхжүүлэх;
- (b) Иргэний харьяалалгүй, ялангуяа Монголдоо буцаж ирсэн Казах хүүхдүүд гэх мэт тус улсын нутаг дэвсгэрт оршин сууж буй бүх хүүхдэд Монгол Улсын иргэний харьяалал олгоход шаардлагатай бүхий л арга хэмжээг авах;
- (c) 1954 онд гарсан Иргэний харьяалалгүй хүмүүсийн статусын тухай конвенц, 1961 оны Иргэний харьяалалгүй байдлыг бууруулах конвенцийг соёрхон батлах талаар анхаарах, эдгээр олон улсын гэрээ конвенцтэй хууль тогтоомжоо уялдуулах.

##### **Хувийн эрх чөлөө**

21. Хувийн нууцын тухай хууль болон Хүүхдийн эрхийн тухай хууль гэх мэт хууль тогтоомжоор хүүхдийн хувийн орон зай, хувийн нууцтай байх эрхийг баталгаажуулсныг сайшаан тэмдэглэхийн зэрэгцээ эцэг эх, эрүүл мэндийн мэргэжилтнүүд, хүүхдийн төлөө болон хүүхэдтэй ажилладаг хувь хүмүүс хүүхдийн энэ эрхэнд бүдүүлгээр халдсаны улмаас зарим үед хүүхэд амиа хорлоход хүргэж болзошгүй учраас хүүхдийн хувийн нууцаа хадгалах, хувийн орон зайтай байх эрхийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээ авахыг тус улсад Хороо зөвлөж байна. Тухайлбал, эцэг эх, эрүүл мэндийн мэргэжилтнүүд, хүүхдийн төлөө болон хүүхэдтэй ажилладаг бусад мэргэжлийн хүмүүс хүүхдийн хувийн нууцаа хадгалах, хувийн орон зайтай байх эрхийн талаар бүрэн зөв ойлголттой болох, энэ эрхэнд хүндэтгэлтэй хандахад сургах тодорхой зөвлөмж журам бий болгох талаар тус улс анхаарах нь зүйтэй.

##### **Тохиромжтой мэдээллийн хүртээмж**

22. Тус улсад интернетийн хэрэглээ хүүхдүүдийн дунд өндөр байгааг тэмдэглэхийн зэрэгцээ өмнөх дүгнэлт зөвлөмжид өгсөн даалгавраа (CRC/C/MNG/CO/3–4, para.36) эргэн сануулахын хамт Интернет болон нийгмийн сүлжээнд тавигдсан хүүхдийн сайн сайхан байдалд хор хохирол учруулах мэдээ материалаас тэднийг хамгаалахад чиглэсэн бүхий л арга хэмжээг авахыг Хороо зөвлөж байна. Бүх хүүхдийн, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, өөр хэлтэй үндэсний цөөнхийн хүүхдүүдийн хэрэгцээг анхаарсан

хүүхдийн нийгэм, оюун санаа, ёс суртахуун, биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийг дэмжсэн контентийг хүүхдэд зориулсан телевизийн нэвтрүүлэг, ном зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслийн олон хэлбэрийг ашиглан хүргэх замаар хүүхдэд тохиромжтой хэрэгтэй мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авахыг мөн зөвлөж байна.

**Е. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл (19, 24 (3), 28 (2),  
34, 37 (а), 39 зүйлүүд)**

**Бие махбодын шийтгэл**

23. Бүх орчинд бие махбодын шийтгэлийг хориглосон заалтыг Хүүхэд хамгааллын болон Хүүхдийн эрхийн тухай хуулиар баталгаажуулсныг сайшаан талархахын зэрэгцээ бие махбодын шийтгэлийг гэр бүл, сургууль зэрэгт өргөнөөр хэрэглэсээр байгаад Хорооны зүгээс сэтгэл ихээр зовинож буйгаа илэрхийлье. Хүүхэд өсгөх, хүмүүжүүлэхдээ хүчирхийллийн биш, эерэг, оролцооны аргыг хэрэглэхийг эцэг эх, багш нарт сургах, үндэсний хэмжээний кампанит ажил өрнүүлэх гэх мэт олон нийтийн боловсролд чиглэсэн арга хэмжээ өрнүүлэх замаар хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарахыг тус улсад зөвлөж байна.

**Хүчирхийлэл үл хайхрах байдал**

24. Архины хамааралтай эцэг эхийнхээ дарамтан дор хүүхдүүд гэртээ бие, сэтгэл санаа, бэлгийн хүчирхийлэл, үл хайхрах байдалд өртөх зэргээр хүүхдүүд хүчирхийлэл, үл хайхрах байдалд өртсөөр байгаад Хороо сэтгэл нэн зовинож буйгаа илэрхийлэн өмнөх зөвлөмжөө (see CRC/C/MNG/CO/3–4, para.47) дахин сануулж дараах арга хэмжээг нэн даруй хэрэгжүүлэхийг шаардаж байна.

- a) Үндэсний хэмжээний хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдүүлэх ажлыг нэн тэргүүнд шийдвэрлэж хүүхдүүдэд үр дүнтэй үйлчилгээ үзүүлж чадах мэргэшсэн чадварлаг нийгмийн ажилтнуудын тоог олноор нэмэгдүүлэх;
- b) Хөвүүдийг бэлгийн хүчирхийлэлд оруулах зэрэг хүчирхийллийн олон хэлбэрийн шалтгаан, мөн чанар, хамрах хүрээг тодорхойлох цогц судалгааг хийх;
- c) Ирсэн гомдол мэдээлэлд хариу өгөх, мөрөөр нь ажиллах үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй байлгахын тулд Хүүхдийн утас 108–ыг шаардлагатай санхүү, арга зүй, хүний нөөцөөр хангахад анхаарах;
- d) Эцэг эхчүүдэд сэтгэлзүйн болон хуулийн зөвлөгөөг үнэ төлбөргүй өгөх.

**Г. Гэр бүлийн орчин ба хүүхдийн асрамж халамжийн  
үйлчилгээ (5, 9–11, 18 (1), (2), 20–21, 25 болон 27 (4) заалтууд)**

**Гэр бүлийн орчин**

25. Хүчирхийлэл, үл хайхрах байдалд өртөх өндөр эрсдэлтэйгээс гадна боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ авах эрх нь зөрчигдөж буй– сүм хийдэд шавилан сууж буй хүүхэд, эцэг эх нь гадаад болон дотоодод шилжин суурьшсаны улмаас бусдын асрамжид амьдардаг хүүхдүүд, дотуур байранд амьдардаг малчдын хүүхэд зэрэг эцэг эхийн хараа

хяналтаас гадуур амьдарч буй хүүхдүүдийн тоо өндөр байгаад Хороо сэтгэл зовнисон хэвээр байна. Мөн гэрээсээ хол газарт, олон цагаар уул уурхайн салбарт ажилладгийн улмаас хүүхдээ үл хайхралд оруулж буй эцэг эхчүүд болон өрх толгойлон амьдардаг хүүхдийн тоо нэмэгдэж буйд Хороо туйлын харамсаж байна.

26. Тус улсад Хорооноос дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

- (a) Санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэх мэтээр эцэг эхчүүд хүүхдээ асарч өсгөх боломжийг нэмэгдүүлэх арга хэмжээгээ бэхжүүлэх;
- (b) Дотуур байранд суудаг болон сүм хийдэд шавилан суудаг гэх мэт эцэг эхийнхээ хараа хяналтад амьдарч чадахгүй байгаа хүүхдүүдтэй ажилладаг хүмүүст чиглэсэн хүүхдийн эрхийн сургалт, ойлголт нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах, гомдол мэдээллээ өгөх үр дүнтэй арга хэрэгсэл, хүүхэд хамгааллын тогтолцоог хүртээмжтэй болгох замаар эдгээр хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авах;
- (c) Өрх толгойлсон хүүхдийн тоог бууруулах, ийм байдалд орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нь дээшлүүлэх зэрэг тэдний хэрэгцээнд нийцсэн боддлого журам гаргахад шаардагдах мэдээллийг хүүхдэд учирч буй тухайлсан бэрхшээл асуудлуудаар нь задаргаа хийн цуглуулах.

#### **Гэр бүлийн орчноос хөндийрсөн хүүхдүүд**

27. Эцэг эхээ алдсан болон тэднээсээ тусдаа амьдрах болсон хүүхдүүдэд чиглэсэн зарим нэг арга хэмжээг тус улс авч хэрэгжүүлдгийг Хорооны зүгээс тэмдэглэхийн зэрэгцээ асрамж халамжийн газарт амьдарч буй хүүхдийн тоонд сэтгэл зовнисон хэвээр байгаа учраас дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

- (a) Асралт гэр бүл, үрчлэлт зэрэг гэр бүлд суурилсан хувилбарт үйлчилгээг орон нутагт нь түшиглэн үзүүлж буй хүчин чармайлтаа улам бэхжүүлэх;
- (b) Хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавих зарчим, хэрэгцээнд суурилан хүүхдийг хувилбарт үйлчилгээнд хамруулах шаардлагатай эсэхийг тогтооход чиглэсэн шалгуур үзүүлэлт, хамгааллын арга хэрэгслээр хангахад анхаарах;
- (c) Асрамж халамжийн газрын ажилтнуудын тоо, мэргэшсэн байдал, зэргийг багтаасан стандартыг гаргаж мөрдүүлэх, асрамж халамжийн газар болон бусад хувилбарт үйлчилгээ үзүүлэгчдийг тогтмол хяналт үнэлгээнд хамруулж тэнд байгаа хүүхдүүдийн нөхцөл байдлыг тогтмол шалгаж байх;
- (d) Ийм хяналт үнэлгээг хийхдээ Ерөнхий ассамблейгаас гаргасан Хүүхдэд зориулсан асрамж халамжийн хувилбарт үйлчилгээний журмыг баримтлах (Ерөнхий ассемблейн тогтоол 64/142, хавсралт).

#### **Үрчлэлт**

28. Гэр бүлийн хуулийг шинэчлэн найруулсныг үнэлэхийн зэрэгцээ үрчлэлтийн практикт хангалттай дэвшил гараагүйд Хороо харамсаж байгаа бөгөөд дараах арга хэмжээнүүдийг яаралтай авахыг шаардаж байна. Үүнд:



- (a) Өмнөх зөвлөмжүүдийг бүрэн биелүүлэх (CRC/C/MNG/CO/3–4, para.45);
- (b) Үрчлэлтийн явцад хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавих зарчим хамгийн чухлыг анхаарах, ялангуяа хүүхдийг үрчлүүлэх шаардлагатай эсэхийг болон үрчилж авч байгаа эцэг эхийн талаар үнэлгээ хийхдээ энэ зарчмыг хатуу мөрдөх;
- (c) Үрчлэлтэд хяналт тавих, үрчлэлтийн мөрөөр ажиллах гэх мэт үрчлэлтийн бүхий л явцад ил тод байдлыг хангах.

**Г. Хөгжлийн бэрхшээл, эрүүл мэнд, нийгмийн халамжийн суурь үйлчилгээнүүд  
(6, 18 (3), 23, 24, 26, 27 (1)–(3) болон 33 зүйл)**

**Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд**

29. 2016 онд батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг онцлон тэмдэглэхийн зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нийгмийн гадуурхалд өртөж байгаа, тэдний амьдралын бүхий л хүрээнд ялгаварлан гадуурхалт учирч буйд Хороо сэтгэл зовнисон хэвээрээ байна. Иймээс тус улсыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог хангах цогц стратегийг хүний эрхэд суурилсан зарчимд тулгуурлан яаралтай баталж дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг шаардаж байна. Үүнд:

- (a) Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах Хорооноос 2015 оны 5 дугаар сард гаргасан зөвлөмжүүдийг бүрэн биелүүлэх (CRPD/C/MNG/CO/1);
- (b) Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүү, арга зүй, хүний нөөцийг хангалттай хуваарилахад анхаарах;
- (c) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан бодлого хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай хөгжлийн бэрхшээлийг оношлох үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх, мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулах;
- (d) Сурагч бүрийн онцлог хэрэгцээнд нийцсэн тэгш хамруулах боловсролыг хөгжүүлэх цогц арга хэмжээнүүдийг авах, улмаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тусгай сургууль, ангид сургахаас илүүтэйгээр тэгш хамруулах боловсролыг чухалчлах;
- (e) Суралцах чадварын бэрхшээлтэй хүүхдүүдэд онцлон анхаарч тэд жирийн хүүхэдтэй хамт нэг ангид сурч байгаа үед тэдэнд ганцаарчласан дэмжлэг үзүүлэх мэргэжлийн багш, ажилтныг сургаж томилох;
- (f) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, сэргээн засах хөтөлбөрт хамруулах зэрэг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг яаралтай авах;
- (g) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг жигшин гадуурхах, тэднээс ичиж зовох гэх мэт үйлдэлтэй тэмцэх, ийм хүүхдүүдийн эерэг дүр төрхийг нийгэмд бүрдүүлэхийн тулд төрийн албан хаагчид, олон нийт, гэр бүлд чиглэсэн ойлголт нэмэгдүүлэх кампанит ажлуудыг өрнүүлэх.

**Эрүүл мэнд ба эрүүл мэндийн тусламж үйлчилгээ**

30. Бүх хүүхдийг эрүүл мэндийн даатгалд үнэ төлбөргүй хамруулах гэх мэт эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх талаар тус улсын авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг талархан тэмдэглэхийн зэрэгцээ хүүхдийн эрүүл мэндийн асуудалд бүс нутаг, нийгэм эдийн засгийн статусаас хамаарсан тэгш бус байдал байсаар байгаа, ялангуяа хөдөөгийн хүүхдүүд эрүүл мэндийн чанартай үйлчилгээ хүртэх боломж дутагдаж буйд Хороо сэтгэл зовнисон хэвээр байгаа тул 2013 онд гаргасан Эрүүл мэндийн хувьд хамгийн өндөр түвшинд хүрсэн үйлчилгээ авах хүүхдийн эрхийг хангах Ерөнхий зөвлөмж 15-ын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг тус улсад зөвлөж байна. Үүнд:

- (a) Бүх хүүхдэд эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй байлгахад чиглэсэн арга хэмжээг нэн яаралтай авах, ялангуяа хөдөөгийн болон орлого багатай гэр бүлийн хүүхдүүдэд хүрэх үйлчилгээний хүртээмжийг эрс сайжруулах;
- (b) Үүрэг хүлээсэн байгууллага, хүмүүс албан бус нэмэлт төлбөр авах гэх мэтээр эрүүл мэндийн үйлчилгээний салбарт гарч буй хээл хахуультай тэмцэх тодорхой арга хэмжээ авах;
- (c) Эрүүл мэндийн чиглэлээр ажилладаг НҮБ-ын Хүүхдийн сан, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага зэргээс санхүүгийн болон арга зүйн дэмжлэг хүсэх.

**Хоол тэжээл**

31. Хүүхдийн хоол тэжээлийн дутагдлыг бууруулах чиглэлээр гаргасан ололт амжилтыг үнэлэхийн зэрэгцээ Хороо өмнөх зөвлөмжөө дахин сануулж (CRC/C/MNG/CO/3-4, para.52) Тогтвортой хөгжлийн зорилтуудын хоол тэжээлийн дутагдлын бүх хэлбэрийг устгах 2.2 зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авахыг зөвлөж байна. Үүнд:

- (a) Таваас доош насны хүүхдүүдийг А болон Д витамин гэх мэт нэн чухал амин дэм, шим тэжээлээр хангахад анхаарах, ялангуяа хөдөөгийн болон орлого багатай өрхийн хүүхдүүд тусгайлан анхаарах, түгээлтийн явцад хоол тэжээлийн зөвөлгөө өгөх ажлыг хавсран явуулах боломжийг бүрдүүлэх;
- (b) Зөвхөн эхийн сүүгээр хооллохын ач тусыг эхчүүдэд сурталчилах гэх мэт үйл ажиллагааг дэмжсэн хангалттай хөрөнгө нөөц бүхий Хөхөөр хооллох үндэсний бодлого боловсруулж батлуулах, одоо мөрдөж буй Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний тухай хуулиа Олон улсын эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний зар сурталчилгаанд тавих ёсзүйн дүрэм болон ДЭМБ-аас гаргасан бусад тогтоол зөвлөмжтэй уялдуулан хэрэгжүүлэх, ажил эрхэлдэг эхчүүдэд хүүхдээ хөхүүлэх боломжийг бүрдүүлэх зэргээр зөвхөн эхийн сүүгээр хооллодог зургаан сар хүртэлх насны хүүхдийн тоог нэмэгдүүлэх;
- (c) Хүүхдийн таргалалтыг бууруулахын тулд хүүхдэд эрүүл биш хүнс, ундааг тэдэнд үйлчилдэг байгууллагуудын ойролцоо байршилтай газруудад сурталчлахгүй байх хууль нэвтрүүлэх, сургуулийн үдийн хоол зэргээр үйлчлэхдээ эрүүл хүнс хэрэглэхийг дэмжсэн тодорхой арга хэмжээг батлах.

**Өсвөр үеийнхний эрүүл мэнд**

32. Өсвөр үеийнхний эрүүл мэндийн асуудлуудын мөн чанар, тархцыг ойлгохын

тулд цогц судалгаа хийж тэдэнд зориулсан эрүүл мэндийн бодлого хөтөлбөр боловсруулах талаарх өмнөх зөвлөмжийг (CRC/C/MNG/CO/3–4, para.54) хэрэгжүүлэх арга хэмжээ аваагүйд Хороо харамсаж буйгаа илэрхийлээд энэ шаардлагыг хойшлуулшгүй нэн даруй биелүүлэхийг Хороо зөвлөж байна. Мөн Хорооны 2016 онд гаргасан өсвөр насныхны хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх тухай Ерөнхий зөвлөмж 20 болон 2003 онд гаргасан Өсвөр үеийнхний эрүүл мэндийн тухай Ерөнхий зөвлөмж 4–т заасныг үндэслэн нөхөн үржихүйн болон бэлгийн эрүүл мэндийн хөтөлбөрийг энэ насны хүүхдүүдийн оролцоотойгоор боловсруулж бие даасан хичээл болгон оруулах, тэдэнд тохирсон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэх талаар хүчин чармайлтаа бэхжүүлэхийг зөвлөж байна.

### **Сэтгэцийн эрүүл мэнд**

33. Хүүхэд амиа хорлох талаар бодох, оролдох гэх мэт сэтгэцийн эрүүл мэндийн асуудал цаашид нэмэгдэх хандлага ажиглагдаж байгаад Хороо сэтгэл зовниж буй бөгөөд өмнөх зөвлөмжид (CRC/C/MNG/CO/3–4, para.56) тусгасан санаануудыг багтаан нөхцөл байдал, үндэс шалтгааны дүгнэлтэд суурилсан, хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний түвшний цогц бодлого боловсруулахыг тус улсад зөвлөж байна. Хүүхдийн сэтгэл зүйгээр тусгайлан мэргэшсэн сэтгэл зүйчдийн тоог нэмэгдүүлэх, сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээнд мэргэшсэн сувилагч гэх мэт анхан шатны үйлчилгээг нэвтрүүлэхийг мөн зөвлөж байна.

### **Орчны эрүүл мэнд**

34. Агаарын хэт бохирдлын талаар тус улсын хийсэн зарим ажлыг тэмдэглэхийн зэрэгцээ ургийн хөгжлийн хоцрогдол, дутуу төрөлт, амьсгалын замын хүнд хэлбэрийн өвчин болон хүндэрч байгаа уушгины үйл ажиллагааны дутагдал, насанд хүрсэн хойно нь илрэх амьсгалын замын архаг өвчин, Монголын 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн хамгийн гол шалтгааны нэг болдог уушгины хатгалгаа зэрэг нь Улаанбаатар хот, ялангуяа гэр хорооллын агаарын бохирдлын улам бүр нэмэгдэж буй түвшний шууд үр дагавар болж байгаад Хороо туйлын харамсаж байна. Мөн уул уурхайн үйл ажиллагаа, хурдацтай хотжилт зэрэг нь хүүхдийн ундны цэвэр усны хүртээмжийг багасгахад нөлөөлж байгаа хөрс усны бохирдлыг бий болгож байна.

35. Хороо өмнөх зөвлөмжөө давтан сануулахын зэрэгцээ (CRC/C/MNG/CO/3–4, para.18(c), para.51(c) and para.58) дараах арга хэмжээнүүдийг нэн яаралтай авахыг тус улсад шаардаж байна. Үүнд:

- (a) Хамгийн наад зах нь HEPA буюу өндөр үр ашигтай агаарын шүүлтүүрийг төрөхийн өмнөх эмнэлгийн тусламжийн багцанд оруулах, өвлийн улиралд халаалтыг нүүрснээс өөр боломжийн үнэтэй өөр түлшээр шийдэх боломжийг нэмэгдүүлэх зэрэг агаарын бохирдлын хор нөлөөг багасгах арга хэмжээг нэн даруй батлах ;
- (b) Хүүхдийг агаарын бохирдлын хор нөлөөнөөс хамгаалах, цэвэр ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэхийг үндэсний бодлогын тэргүүлэх чиглэл гэдгийг зарлаж орчны бохирдлын хүүхдэд үзүүлж буй сөрөг

нөлөөг үр дүнтэй бууруулахын тулд санхүү, арга зүй, хүний нөөцийг хангалттай хувиарлах;

- (с) Орон нутгийн түвшинд ажиллаж байгаа албан хаагчдыг агаар, усны бохирдлыг хянах, зохицуулах мэдлэг, чадвар, арга зүйгээр хангахад анхаарах.

### **Цаг уурын өөрчлөлтийн хүүхдийн эрхэд нөлөөлж буй байдал**

36. Тус улсын эмзэг эко системд нөлөөлж байгаа цаг уурын өөрчлөлт, хүйтэн ширүүн өвөл нь малчин өрхүүд мал сүргээ олноор нь алдан гарз хохиролд ороход хүргэж буй нь хүүхдүүдэд нь шууд сөргөөр тусаж байгааг дурдахын хамт Тогтвортой хөгжлийн зорилтуудын 13.5-т байгаа цаг уурын өөрчлөлттэй холбоотой үр дүнтэй төлөвлөлт, удирдлагын чадварыг дээшлүүлэх механизмыг сайжруулах зорилтын хүрээнд цаг уурын өөрчлөлттэй тэмцэх, дасан зохицоход чиглэсэн хүүхдэд түшиглэсэн арга зүйг нэвтрүүлж, бодлого төлөвлөгөө гаргахдаа хүүхдийг оролцуулахыг зөвлөж байна.

### **Амьдралын чанар**

37. Тус улсад ядуурал байсаар байгаа болохоор олон хүүхдийн амьдралын ерөнхий түвшин доогуур байгаад Хороо сэтгэл зовниж байгаа бөгөөд тус улсыг ядуурал болон алслагдмал газар, хөдөө нутаг, төв суурин газрын ядуусын хорооллын хүүхдүүдэд цэвэр усны хүртээмж, ариун цэврийн байгууламжийн хүртээмж дутагдалтай байгааг шийдвэрлэх хүчин чармайлтаа идэвхжүүлэхийг зөвлөж байна. Мөн дараах зөвлөмжийг Хорооноос өгч байна. Үүнд:

- (а) Тогтвортой хөгжлийн зорилт 3-т дурдсан бүх нийтэд зориулсан үндэсний хэмжээний нийгмийн хамгааллын тогтолцоо, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилтыг үндэслэн тэгш бус байдлын үндсэн шалтгааныг тогтоох судалгаа хийх, хамгийн хүнд нөхцөлд байгаа хүүхдүүдэд хөрөнгө нөөцийг шууд чиглүүлсэн татварын шинэлэг, үр дүнтэй түгээлтийн бодлого хэрэгжүүлэх;
- (б) Эдийн засаг, нийгэм, соёлын Хорооны (E/C.12/MNG/CO/4, para.22) болон Хүний эрх, нэн ядуу байдлын талаар ажилладаг тусгай төлөөлөгчийн (A/HRC/23/36/Add.2) зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлэх.

## **Н. Боловсрол, чөлөөт цаг, соёлын арга хэмжээ (28, 29, 30 болон 31 зүйл)**

### **Боловсрол**

38. Өмнө өгсөн зарим зөвлөмжийг (CRC/C/MNG/CO/3-4, para.60) хэрэгжүүлэхийн төлөө гаргасан тус улсын чармайлтыг онцлохын зэрэгцээ үндэслэн Засгийн газрын боловсролын бодлого уялдаа холбоогүй, тууштай биш байсан нь нэн даруй шийдэх ёстой маш чухал асуудлуудын явцыг удаашруулж байгаад Хороо сэтгэл зовниж байгаа учраас Боловсролын зорилгын тухай 2001 оны Ерөнхий зөвлөмж 1-ийг үндэслэн дараах зөвлөмжүүдийг заавал хэрэгжүүлэхийг шаардаж байна. Үүнд:

- (а) Бүх түвшинд, бүх хүүхдэд боловсролын хүртээмж тэгш байхыг баталгаажуулах хүчин чармайлтаа бэхжүүлэх, ялангуяа Казах хүүхдүүд гэх мэт үндэсний болон хэлний цөөнх хүүхдүүд, бага орлоготой өрхийн хүүхдүүд, малчин өрхийн

хүүхдүүд, алслагдсан хөдөө нутгийн хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, хөвүүд, ялангуяа сүм хийдэд шавилан сууж байгаа хүүхдүүдэд илүү анхаарал хандуулах;

- (b) Жирэмсэн охид болон өсвөр насны эхчүүд боловсролоо ердийн сургуульд үргэлжлүүлэхэд нь дэмжин туслах;
- (c) Магадлан итгэмжлэгдсэн цахим хичээл, хөтөлбөр, явуулын сургуульд малчдын хүүхдүүдийг хамруулах зэргээр дотуур байранд суулгүйгээр суурь боловсрол эзэмшиж болох хувилбарыг олж хэрэгжүүлэх;
- (d) Суурь болон дунд боловсролын хүртээмж, тасралтгүй үргэлжлүүлэн сурах боломжийг дээшлүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээг авах, цэвэр ус, ариун цэврийн байгууламж гэх мэт дэд бүтэц, сургалтын хэрэглэгдэхүүн, сургуульдаа ирэх буцах унаа, чанартай багшийн хүрэлцээ зэрэгт анхаарах;
- (e) Хүмүүжлийн эерэг, хүчирхийллийн биш аргыг сургалтдаа ашигладаг болгохын тулд багш нарыг сургах гэх мэтээр хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хамгаалах механизмыг бүрдүүлэн бүх түвшний сургуульд сурч буй хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх арга хэмжээг бэхжүүлэх;
- (f) Бага насны хүүхдийн хөгжил, асаргааны цогц, нэгдсэн бодлогод суурилан сургуулийн өмнөх боловсролыг хөгжүүлэх, хүртээмжийг нь нэмэгдүүлэхийн тулд хангалттай төсөв санхүү хуваарилах.

#### **Амралт, чөлөөт цаг, зугаа цэнгэл, соёл, урлагийн арга хэмжээ**

39. Сургууль дээр хичээлээс гадуур арга хэмжээг зохион байгуулах талаар бодлогын баримт бичиг батлах зэргээр хүүхдийн чөлөөт цагийн арга хэмжээний хүртээмжийг нэмэгдүүлэх талаар санаачилгатай ажилласанд талархахын зэрэгцээ хүүхдийн насанд тохирсон соёл, урлаг, амралт, чөлөөт цагийн арга хэмжээг явуулах газар, боломжууд дутагдаж буйд Хороо сэтгэл зовнисон хэвээр байна. Иймээс өмнөх зөвлөмжийг (CRC/C/MNG/CO/3-4, para.62) хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө нөөцийг хангалттай хуваарилахыг тус улсад сануулж байна.

#### **I. Тусгай хамгааллын арга хэмжээнүүд (22, 30, 32–33, 35–36, 37 (b)–(d), 38, 39 болон 40–р зүйлүүд)**

##### **Хүүхдийн хөдөлмөр, унаач хүүхэд зэрэг эдийн засгийн мөлжлөг**

40. 2016 он гэхэд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөр гаргасан, Хөдөлмөрийн хуулийг шинэчлэн найруулсан зэрэг хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх чиглэлийн арга хэмжээг тус улс авсанд Хороо талархахын зэрэгцээ хүүхдүүд хөдөө аж ахуй, уул уурхай, морин уралдаан зэрэг аюултай, хортой нөхцөлд хөдөлмөр эрхэлсээр байгаад сэтгэл маш их зовниж байна. Жил бүрийн 11 дүгээр сарын 1–ээс тавдугаар сарын 1–нийг хүртэлх хугацаанд уралдаан, сунгаа, үсэргээнд 16–аас доош насны хүүхдээр хурдан морь унуулахыг Монгол Улсын Хөдөлмөрийн сайдын 2016 оны хоёрдугаар сарын 8–ны өдрийн А/36 тушаалаар хориглосон байсныг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд 2017 онд хүчингүй болгосон, мөн морины эзэд, уяачдын

зүгээс учруулсан бие махбод, сэтгэл санааны хүчирхийлэлд өртөх, сургууль завсардах, гэмтэж бэртэх, амь насаа алдах эрсдэлд унаач хүүхдүүд өртсөөр байгаад Хороо маш их харамсаж байна.

41. Хороо өмнө өгсөн зөвлөмжөө (CRC/C/MNG/CO/3-4, para.65) дахин сануулж дараах арга хэмжээг яаралтай авахыг тус улсад шаардаж байна. Үүнд:

- (a) 2012–2016 онд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөрийн санхүү төсөв, менежмент хангалтгүй байсны улмаас уг хөтөлбөр сайн хэрэгжээгүйд дүгнэлт хийж Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үйл ажиллагааны цогц төлөвлөгөө, бодлогыг хангалттай төсөв санхүү, арга зүй, хүний нөөцтэйгээр батлах;
- (b) 15–аас доош насны хүүхэд хөдөлмөр эрхлэхгүй байхад анхаарч шинэчлэн найруулсан Хөдөлмөрийн хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх;
- (c) Жил бүрийн 11 дүгээр сарын 1–нээс тавдугаар сарын 1–нийг хүртэлх хугацаанд 16–аас доош насны хүүхдээр хурдан морь унуулахыг хориглосон шийдвэрийг 18 наснаас доош хүүхдээр хурдан морь унуулахыг хориглох үйл явцын эхний алхам гэж үзэн хэрэгжилтийг нь сахиулахад хатуу анхаарах
- (d) Хурдан морины уралдаанд оролцож байгаад хүндээр гэмтсэн амь насаа алдсан хүүхдүүдийн хэргийг мөрдөн шалгаж буруутай этгээдэд хариуцлага ноогдуулах;
- (e) Хурдан морины уралдаан гэх мэт аюултай, хортой хүүхдийн хөдөлмөрт хүүхдийг оролцуулдаг бизнес эрхлэж буй төрийн албан хаагчдын хувийн болон албаны ашиг сонирхлын зөрчил гаргаж буй үйлдэлд арга хэмжээ авах, ийм үйлдэл гаргуулахгүй байхад чиглэсэн хээл хахуулийн эсрэг арга хэмжээнүүдийг авах.

#### **Гудамжны нөхцөлд амьдарч буй хүүхдүүд**

42. Гудамжны нөхцөлд амьдарч байгаа хүүхдийг бүртгэлжүүлж хамгаалах чиглэлээр Засгийн газрын 2016–2020 оны хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын “Хараа хяналтгүй хүүхдийн талаар авах зарим арга хэмжээний тухай” А/847 захирамж гаргасан, Хараа хяналтгүй хүүхдэд зориулсан хөгжлийн төв байгуулах төлөвлөгөө баталсан зэрэг ажлыг Хороо үнэлэхийн зэрэгцээ хүүхэд гудамжинд амьдарч байгаагийн үндэс шалтгааны талаар мэдээлэл, найдвартай зөв статистикийн тоо баримт байхгүй байгаа талаар өмнөх зөвлөмжөө (CRC/C/MNG/CO/3-4, para.67) дахин сануулж байна. Мөн Гудамжны нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн талаарх Хорооноос 2017 онд гаргасан Ерөнхий зөвлөмж 21–ийг үндэслэн дараах арга хэмжээг нэн даруй авахыг тус улсад шаардаж байна:

- a. Хот хөдөөд гудамжны нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн талаарх нарийн задаргаатай мэдээлэл цуглуулах;
- b. Хүүхдийг гудамжинд гаргахад хүргэж байгаа үндэс шалтгааныг илүү ойлгохын тулд нөхцөл байдлын үнэлгээ хийх, судалгааны дүн мэдээг олон нийтэд танилцуулах;
- c. Гудамжны нөхцөлд байгаа бүх хүүхдийг эргэн нэгтгэх, нөхөн сэргээх, хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр хоорондоо уялдаа холбоотой, тогтвортой арга хэмжээнүүдийг боловсруулахын тулд Үндэсний хэмжээний бодлого, зохицуулах хүрээг тодорхойлж хангалттай төсөв хөрөнгө хувиарлах;

- d. Гудамжны нөхцөлд байгаа хүүхдүүдийн боловсрол, эрүүл мэнд, амьдралын наад захын стандартыг хүртэх эрхийг хангахын тулд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын тогтолцоо тэдний онцлог хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлдэг байхад чиглэсэн бүх арга хэмжээг авах;
- e. Хүүхдийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих зарчимд нийцэж байвал хүүхдүүдийг аль болохоор гэр бүлд нь эргэн нэгтгэх.

#### **Насанд хүрээгүй хүүхдийн хэргийг шийдвэрлэх**

43. Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгийн (A/HRC/30/6, para.108.162 and A/HRC/30/6/Add.1) тайландаа насанд хүрээгүй хүүхдийн хэргийг шийдвэрлэх, олон улсын стандартад нийцсэн цогц бодлогын хүрээг бүрдүүлнэ гэж тус улс амласныг сануулахын ялдамд энэ амлалтаа нэн даруй биелүүлэхийг Хороо тус улсад шаардаж байна. Мөн өмнөх дүгнэлт зөвлөмжийг (CRC/C/MNG/CO/3-4, para.76), мөн эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн Хорооноос 2016 онд өгсөн зөвлөмжийг (CAT/C/MNG/CO/2, para.24) биелүүлэхийг зөвлөж байна. Тухайлбал, дараах арга хэмжээг нэн даруй авахыг тус улсад Хорооноос шаардаж байна. Үүнд:

- (a) ХЭК-ийн зарчмууд, зүйл заалтуудын талаар зохих сургалтад хамрагдсан хүүхдийн мэргэжсэн шүүгчдийг тусгайлан томилдог байх;
- (b) Төлбөрийн чадваргүй хүүхдүүдэд үнэ төлбөргүй хуулийн зөвлөгөө өгөх гэх мэт хууль зөрчсөн хүүхдэд хууль зүйн мэргэжлийн, бие даасан, чанартай тусламж үйлчилгээ үзүүлэхэд анхаарах;
- (c) Эрүүгийн хууль зөрчсөн гэж сэжиглэгдэж байгаа хүүхдийг батлан даалтад өгөх, тэнсэх, эвлэрүүлэн зуучлах, зөвлөгөө өгөх, нийтэд тустай ажил хийлгэх гэх мэтээр шүүхээр оруулахгүйгээр хэргийг нь шийдвэрлэдэг арга барилыг (diversion) бэхжүүлэх, хэрвээ ял шийтгэл оногдуулах бол аль болохоор хорихоос өөр хувилбарыг ашиглах, хорих ялыг хамгийн сүүлчийн арга хэмжээ болгон, байж болох хамгийн бага хугацаагаар хорих гэсэн хувилбараар ашиглах, ийм ял өгсөн бол ялыг цуцлах боломжтой юу гэсэн үндэслэлээр хэргийг тогтмол магадлангаар оруулж байх;
- (d) Хорих ялыг онохоос өөр аргагүй үед хүүхдийг насанд хүрэгчидтэй хамт хорихгүй, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ хүртээмжтэй байх гэх мэт олон улсын стандартад хорих газрын нөхцөл байдал нийцсэн байхад анхаарах.

Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай Конвенцэд оруулах нэмэлт протоколын хэрэгжилтийн талаар Хорооны өмнөх зөвлөмжийн мөрөөр хэрхэн ажилласанд өгөх дүгнэлт зөвлөмжүүд

44. Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай Конвенцэд оруулах нэмэлт протоколын хэрэгжилтийн талаар тус улсын анхны тайланд Хорооноос 2010 оны 3-р сарын 3-ны өдөр өгсөн дүгнэлт зөвлөмжийн (CRC/C/OPSC/MNG/CO/1) хэрэгжилтийн талаар хангалтгүй мэдээлэл өгсөнд харамсаж байгаагаа илэрхийлээд тэрхүү зөвлөмжийг

биелүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авахыг зөвлөж байна. Тухайлбал, (CRC/C/OPSC/MNG/CO/1, para.7), Нэмэлт протоколын 2 болон 3–р зүйлд нийцүүлэн хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахыг гэмт хэрэг гэж тодорхойлон хуульчлах, мэдээлэл цуглуулах (CRC/C/OPSC/MNG/CO/1, para.9), хохирогчдыг нөхөн сэргээх, эргэн нэгтгэх (CRC/C/OPSC/MNG/CO/1, para.31) арга хэмжээг яаралтай хэрэгжүүлнэ үү. Мөн дараах зөвлөмжийг тус улсад нэмж өгч байна. Үүнд:

- (a) Хүүхдийн секс аялал жуулчлалыг устгах, үүнээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн зохицуулалтын үр дүнтэй хүрээг тогтоож, хууль, захиргаа, нийгэм болон бусад бүх шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх;
- (b) Цахим орчинд хүүхдийг хамгаалах чиглэлээр төр–хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх гэх мэтээр интернет орчин дох хүүхдийн аюулгүй байдлыг хангах механизмыг үр дүнтэй хэрэгжүүлэх.

Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг Хүүхдийн эрхийн конвенцэд оруулах нэмэлт протоколын тайланд өгсөн өмнөх зөвлөмж дүгнэлтийн мөрөөр хийсэн ажилд өгөх дүгнэлт зөвлөмж

45. Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг Хүүхдийн эрхийн конвенцэд оруулах нэмэлт протоколын хэрэгжилтийн талаар ирүүлсэн тус улсын анхны тайланд Хорооноос 2010 оны 3–р сарын 3–ны өдөр өгсөн дүгнэлт зөвлөмжийн (CRC/C/OPAC/MNG/CO/1) хэрэгжилтийн талаар маш хангалтгүй мэдээлэл өгсөнд харамсаж байгаагаа илэрхийлээд тэрхүү зөвлөмжийг биелүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авахыг зөвлөж байна. Тухайлбал, цэргийн сургууль (CRC/C/OPAC/MNG/CO/1, para.11), эрүүгийн хууль тогтоомж (CRC/C/OPAC/MNG/CO/1, para.14) гэх мэт асуудлаар тодорхой арга хэмжээ авна уу. Мөн нэмэлт протоколын 4–р заалтыг үндэслэн төрийн зэвсэгт хүчнээс ангид цэрэгжсэн бүлэглэлүүдийн зохион байгуулж буй байлдааны ажиллагаанд 18 нас хүрээгүй хүүхдийг оролцуулахыг гэмт хэрэг гэж хуульчлахыг зөвлөж байна.

#### **J. Олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийг соёрхон баталсан байдал**

46. Хүүхдийн эрхийг бүрэн дүүрэн хангахын тулд тус улс нь Бүх цагаач ажилчид, тэдний гэр бүлийг хамгаалах олон улсын конвенцийг соёрхон батлахыг Хороо зөвлөж байна.

### **IV. Хэрэгжилт ба тайлагналт**

#### **A. Зөвлөмжийг түгээх, түүний мөрөөр ажиллах**

47. Энэхүү зөвлөмж дүгнэлтэд багтаасан зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээ авахыг тус улсад Хороо зөвлөж байна. Мөн Тавдугаар тайлан, түүний мөрөөр Хорооноос асуусан асуултад бичгээр өгсөн хариулт болон энэхүү



Зөвлөмж дүгнэлтийг тус улсад хэрэглэгддэг бүх хэл дээр гаргаж өргөнөөр түгээхийг зөвлөж байна.

### **В. Тайлагнах, зөвлөмжийн мөрөөр ажиллах үндэсний механизм**

48. Олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн байгууллагуудтай хамтран ажилладаг, хүний эрхийн гэрээ конвенцүүдийн биелэлтийн талаар тэдгээр байгууллагуудын өгсөн шийдвэр, зөвлөмж дүгнэлтийн мөрөөр ажилладаг, үндэсний хэмжээний хэрэгжилтийг нь бүртгэж баримтжуулж байдаг, тэдгээрт явуулах тайлангуудыг бэлтгэх, зохицуулах ажлыг хариуцах үүрэг чиглэл бүхий Тайлагнах, зөвлөмжийн мөрөөр ажиллах үндэсний механизмыг Засгийн газрын байнгын бүтэц хэлбэрээр бий болгохыг Хороо зөвлөж байна. Энэ бүтэц нь яг энэ ажил үүргийг хариуцсан ажилтныг тогтмол ажиллуулах төсөв нөөцтэй, Хүний эрхийн үндэсний комисс болон иргэний нийгмийн байгууллагуудтай байнга зөвлөлдөх чадвартай байх ёстойг онцолж байна.

### **С. Дараагийн тайлан**

49. Тус улсыг 6 болон 7-р дугаар тайлангаа нэгтгэн бичиж 2022 оны 9 сарын 1 гэхэд ирүүлэхийг Хороо урьж байна. Нэгдсэн тайланд энэхүү зөвлөмж дүгнэлтээр өгсөн зөвлөмжүүдийн мөрөөр хэрхэн ажилласан талаар мэдээллээ багтаасан байна. Тайланг бичихдээ Хорооноос 2014 оны 1 сарын 31-ний өдөр гаргасан тусгайлсан гэрээ конвенцийн тайлан бичих журмыг (CRC/C/58/Rev.3) баримтлан 21,200 үгээс (General Assembly resolution 68/268, para. 16) хэтрүүлэхгүй бичнэ. Хэрвээ ирүүлсэн тайлан нь тогтоосон үгийн тооноос давсан байвал дээр дурдсан тогтоолын дагуу тайлангаа товчлон бичихийг хүсэх болно. Хэрвээ тухайн улс тайлангаа дахин хянаад буцааж ирүүлэхгүй бол тайланг хэлэлцэхгүй болно.

50. Мэдээлэл нь хуучраад байгаа үндсэн баримт бичгээ 42,400 үгэнд багтаан шинэчлэн ирүүлэхийг мөн Хороо тус улсад уриалж байна. Хүний эрхийн гэрээ, конвенцийн тусгайлсан тайлан болон үндсэн баримт бичгийг холбогдох журамд заасан шаардлагуудын (HRI/GEN/2/Rev.6, chap. I) and paragraph 16 of General Assembly resolution 68/268) дагуу тайлангуудыг бичиж ирүүлнэ үү.

## 6.8 ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦИЙН ХҮҮХДИЙГ ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНД ОРОЛЦУУЛАХЫН ЭСРЭГ НЭМЭЛТ ПРОТОКОЛЫН НАЙМДУГААР ЗҮЙЛИЙН ДАГУУ ГИШҮҮН ОРНЫ ӨРГӨН БАРЬСАН ТАЙЛАНГИЙН ЗӨВЛӨМЖ

### **Зөвлөмж: Монгол Улс**

1. Хүүхдийн Эрхийн Хороо нь 2010 оны нэгдүгээр сарын 12, 13-нд болсон 1458, 1460 дүгээр хуралдаанаар (CRC/C/SR. 1458 болон CRC/C/SR. 1460), Монгол Улсын анхны илтгэлийг (CRC/C/OPAC/MNG/1) хэлэлцэж, 2010 оны нэгдүгээр сарын 29-ны өдрийн 1501 дүгээр хуралдаанаар дараах зөвлөмжийг гаргав.

### **Оршил**

2. Тус Хороо нь Монгол улсын анхны тайлан илтгэл ирүүлсэн болон асуултад хариу өгсөн явдалд талархаж байна. Мөн өндөр хэмжээний төлөөлөгчид ирж уулзсанд талархаж буйгаа илэрхийлье. Гэхдээ, Гишүүн улсын тайлан илтгэл нь Протоколын илтгэл бичих тухай шинэчилсэн удирдамжийг мөрддөггүй, хэт товч, төлөөлөгч нарын дунд Хууль зүй Яам болон Батлан Хамгаалахын Яамны төлөөлөл байлцаагүй явдалд харамсаж байна.

3. Гишүүн улс энэхүү дүгнэлт зөвлөмжийг, 2010 оны нэгдүгээр сарын 29-ний өдөр гаргасан CRC/C/MNG/CO/3-4-д багтсан Гишүүн улсын нэгтгэсэн гурав дөрөвдүгээр тайлан илтгэлийн дүгнэлт, зөвлөмжийн хамт уншихыг сануулж байна.

### **А. Эерэг хүчин зүйл**

4. Монгол Улс хууль (Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, 9 дүгээр зүйл, 2 дугаар заалт)-даа 18-аас доош насны хүнийг цэрэг таталгад албадан хамруулахгүй байхаар заасныг Хорооноос талархан хүлээн авч байна.

5. Гишүүн улс дараах олон улсын эрх зүйн актуудыг соёрхон баталсанд Хороо талархаж байна:

- (а) 2003 онд Хүүхдийн Эрхийн тухай Конвенцийн Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Нэмэлт Протокол;
- (б) 2001 оны есдүгээр сард Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй, хүнд хэлбэрийг устгах ОУХБ-ын 182 дугаар Конвенц;
- (в) 2002 онд Олон улсын гэмт хэргийн шүүхийн талаарх Ромын дүрэм

## I. Холбогдох зарчмын асуудал болон зөвлөмж

### Түгээх болон сурталчлах

6. Нэмэлт Протоколыг Монгол хэлээр орчуулж, үүнийгээ зэвсэгт хүчин, хүүхдийн байгууллагын ажилтнуудад тараах үйл хэрэгт оруулсан Гишүүн орны хүч чармайлтыг Хороо талархан тэмдэглэж байна. Гэвч олон нийтийн дунд Протоколын зарчим заалтын талаар мэдлэг, мэдээлэл дутмаг байгаад сэтгэл дундуур байна.

7. Протоколын 6 дугаар зүйлийн 2-т заасны дагуу, Гишүүн улс энэхүү Протоколыг олон нийт, тэр дундаа хүүхэд болон тэдний эцэг эхчүүдэд өргөн хүрээнд таниулах талаар хүч чармайлтаа нэмэгдүүлэхийг Хорооноос зөвлөж байна.

### Сургалт

8. Монголын энхийг сахиулагч нарт Хүүхдийн Эрхийн тухай Конвенц болон түүний Нэмэлт Протокол зэрэг олон улсын хүний эрх болон хүмүүнлэгийн стандартын талаар сургалт явуулж байгаа талаарх мэдээллийг Хороо талархан хүлээн авч байна. Хэдий тийм ч, шүүх тогтолцоонд ажиллаж буй хүмүүс, хууль сахиулах байгууллагын ажилтнууд, Монголын зэвсэгт хүчнийхэнд зориулж Протоколын зүйл заалтын талаар системтэй сургалт явуулахгүй байгаад сэтгэл зовниж байна.

9. Протоколын зүйл заалтын талаар зэвсэгт хүчнийхэнд зориулсан сургалтын арга хэмжээг зохион байгуулах ажлаа сайжруулахыг Хороо Гишүүн улсад зөвлөж байна. Прокурор, хуульч, шүүгч, хууль сахиулах ажилтан, нийгмийн ажилтан, эрүүл мэндийн ажилтан, багш, хэвлэл мэдээллийн ажилтан, аймаг орон нутгийн засаг дарга нар зэрэг хүүхэдтэй ажилладаг холбогдох мэргэжлийн бүлэгт зориулж Протоколын зүйл заалтын талаар сургалтын хөтөлбөр боловсруулах ажлаа сайжруулахыг Хороо Гишүүн улсад зөвлөж байна.

## II. Урьдчилан сэргийлэх

### Цэргийн сургууль

10. Батлан Хамгаалахын Их Сургууль, хөгжмийн сургууль, хилийн тусгай бүс, хороонд байгаа сурагч нараас гаргаж болох гомдлыг шийдлвэрлэх бие даасан механизм байхгүй байгаад сэтгэл зовниж байна.

11. Цэргийн сургуульд сурдаг хүүхдүүд хүүхдийн эрхийн зөрчлийн талаар бие даан гомдол мэдүүлэх, түүнийг нь хянах шалгах механизмыг хүртээмжтэй болгохыг Хороо зөвлөж байна.

### Энх тайвны боловсрол

12. Хүний эрхийн болоод энх тайвны боловсролыг хүүхдийн сургалтын хөтөлбөрт багтаах зэргээр энх тайван, харилцан ойлголцол, итгэлцлийн орчинг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаагаа бэхжүүлэхийг Гишүүн улсад Хороо зөвлөж байна.

### III. Хориглосон болон бусад арга хэмжээнүүд

#### Эрүүгийн хууль тогтоомж болон дүрэм журам

13. Гишүүн орны Эрүүгийн хууль нь зэвсэгт мөргөлдөөнд хүүхдийг татан оролцуулахыг хориглох зэрэг Протоколын заалтуудын зарим хэсгийг хэрэгжүүлж байгаа ч гэсэн хүүхдийг дайны үйл ажиллагаанд оролцуулахгүй байх талаар тусгай эрх зүйн заалт байхгүй байгаад Хороо сэтгэл зовниж байна.

14. Хороо Гишүүн улсад дараахь зүйлүүдийг зөвлөж байна.

- (a) Гишүүн улс өөрийн хууль тогтоомждоо Нэмэлт Протоколын заалтыг зөрчин хүүхдийг дайны үйл ажиллагаанд дайчлах, оролцуулах нь гэмт хэрэг мөн гэж нарийвчлан тусгах
- (b) Цэргийн ёс зүйн хэм хэмжээ, гарын авлага, цэргийн дүрэм журам нь Нэмэлт Протоколын заалт зарчимтай нийцэж буйг баталгаажуулах

### IV. Олон улсын хамтын ажиллагаа тусламж

#### Олон улсын хамтын ажиллагаа

15. Гишүүн улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах үйлсэд идэвхтэй хувь нэмэр оруулж байгаад Хороо талархаж байна.

16. Зэвсэгт мөргөлдөөнд оролцож буй хүүхдийн эрхийн талаар Гишүүн орны зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн бүрэн дүүрэн мэдлэгтэй байж, цэргийн ажилтнууд өөрсдийн үүрэг хариуцлагыг мэдэж байгаа эсэхэд анхаарахыг Хороо зөвлөж байна.

### V. Зөвлөмжийн түгээх болон хэрэгжүүлэх

#### Зөвлөмжийг хэрэгжүүлэх

17. Энэхүү зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авах, тэр дундаа зөвлөмж нь Улсын Их Хурал, Батлан Хамгаалах яам, аймаг нийслэлийн Засаг дарга, иргэдийн хурлын дарга нарт хүрсэн, тэдний үйл ажиллагаанд тусгалаа олсон байх бүх арга хэмжээг авахыг Гишүүн улсад Хороо зөвлөж байна.

#### Түгээх

18. Нэмэлт Протокол болон түүний хэрэгжилт, хяналтын талаар мэтгэлцээн өрнүүлж мэдлэг дээшлүүлэх үүднээс Гишүүн улсын гурав, дөрөвдүгээр тайлан, бичгээр өгсөн хариулт болон дүгнэлт зөвлөмжийг олон нийтэд хүртээх.

### VI. Дараагийн тайлан

19. Конвенцийн 44 дүгээр зүйлийн дагуу, Хүүхдийн Эрхийн тухай Конвенцийн хэрэгжилтийн талаарх тав дахь тайлан илтгэлийг өгөхдөө 8 дугаар зүйлийн 2 дугаар заалтын дагуу энэхүү Нэмэлт Протоколын хэрэгжилтийн талаарх нэмэлт мэдээллийг оруулахыг Гишүүн улсаас хүсч байна.

**6.9 ХҮҮХДИЙГ ХУДАЛДАХ, ХҮҮХДИЙН БИЕИЙГ ҮНЭЛЭХ,  
ХҮҮХДИЙГ САДАР САМУУНД СУРТАЛЧЛАХЫН ЭСРЭГ ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ  
КОНВЕНЦИЙН НЭМЭЛТ ПРОТОКОЛЫН 12(1) ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН ДАГУУ ГИШҮҮН  
ОРНЫ ӨРГӨН БАРЬСАН АНХДУГААР ТАЙЛАНГИЙН ЗӨВЛӨМЖ**

**Зөвлөмж: Монгол Улс**

1. Хүүхдийн Эрхийн Хороо нь Монгол Улсын анхны илтгэлийг (CRC/C/OPSC/MNG/1) 2010 оны 1 дүгээр сарын 12, 13 болсон 1458, 1460 дүгээр хуралдаанаар (CRC/C/SR. 1458 болон CRC/C/SR. 1460), хэлэлцэж, 2010 оны 1 дүгээр сарын 29–ны өдрийн 1501 дүгээр хуралдаанаар дараахь зөвлөмжийг гаргав.

**Оршил**

2. Монгол Улсын анхны тайлан илтгэл болон Хорооны тавьсан асуулгад хариулт өгсөн явдалд Хороо талархаж байна. Мөн өндөр хэмжээний төлөөлөгчид хүрэлцэн ирж үр дүнтэй уулзалт хийсэн явдалд талархаж буйгаа илэрхийлье. Гэвч, Гишүүн улсын тайлан илтгэл нь Протоколын илтгэл бичих тухай шинэчилсэн удирдамжийг мөрдөөгүй, төлөөлөгч нарын дунд Хууль зүйн яамны төлөөлөл байлцаагүй явдалд харамсаж байна.

3. Энэхүү дүгнэлт зөвлөмжийг, 2010 оны 1 дүгээр сарын 29–ний өдөр гаргасан CRC/C/MNG/CO/3–4–д багтсан Гишүүн улсын нэгтгэсэн гурав, дөрөвдүгээр тайлан илтгэлийн дүгнэлт зөвлөмжийн хамт уншихыг Гишүүн улсад сануулж байна.

**I. Ерөнхий дүгнэлт, зөвлөмж**

**A. Эерэг хүчин зүйлс**

4. Иргэний нийгмийн байгууллага болон хүүхдүүд зэрэг холбогдох талуудыг энэхүү тайланг бэлтгэх үйл явцад оролцуулсан явдлыг Хороо талархан хүлээн авч байна.

5. Гишүүн улс дараах олон улсын эрх зүйн актуудыг соёрхон баталсанд Хороо талархаж байна:

- (a) 2006 онд Хүүхдийг Зэвсэгт Мөргөлдөөнд оролцуулахын эсрэг конвенцийн Нэмэлт Протокол
- (b) 2001 оны 9–р сард Хүүхдийн Хөдөлмөрийн тэвчишгүй хүнд хэлбэрийг устгах ОУХБ–ын 182 дугаар Конвенц
- (c) 2008 онд Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ–ын конвенцийн Хүнийг ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдийг хил дамжуулан худалдахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, шийтгэл ноогдуулах тухай Нэмэлт Протокол

**II. Мэдээллийн сан**

**Мэдээлэл цуглуулах**

6. Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлах явдлын хамрах хүрээний талаар статистик мэдээлэл судалгаа хязгаарлагдмал байгаад Хороо сэтгэл зовниж байна.

7. Энэхүү Протоколд багтсан асуудлуудын талаар судалгаа хийж, хүйс, нас, нийгэм–эдийн засгийн гарал, газар зүйн байрлал, үндэсний цөөнх зэргээр тоо баримтыг нарийвчлан, бодлого хэрхэн хэрэгжиж байгааг үнэлэхэд шаардлагатай мэдээллийг системтэйгээр цуглуулж, дүгнэлт хийхийг Гишүүн улсад Хороо зөвлөж байна. Гишүүн улс

НҮБ–ын Хүүхдийн Сан зэрэг НҮБ–ын харьяа байгууллага, хөтөлбөрүүдээс энэ тал дээр тусламж авах боломжтой.

### **III. Протоколыг хэрэгжүүлэхээр авсан ерөнхий арга хэмжээ**

#### **Хууль тогтоомж**

8. Монгол улс өөрийн хууль тогтоомждоо энэхүү Протоколын зарим зүйл заалтыг тусгасан талаар мэдээллийг Хороо талархан хүлээн авч байна. Гэвч, нарийвчилсан тодорхойлолт байхгүй, Протоколд заасан бүх гэмт үйлдлүүдийг бүгдийг нь оруулаагүй явдалд сэтгэл зовниж байна.

9. Гишүүн улс өөрийн орны хууль тогтоомжийг энэхүү Протоколын зарчим, зүйл заалттай уялдуулах үйл явцыг үргэлжлүүлж, бүрэн хэрэгжүүлэхийг Хороо зөвлөж байна.

#### **Үндэсний хэмжээний үйл ажиллагааны төлөвлөгөө**

10. Хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор хил дамнуулан худалдахаас хамгаалах үндэсний хөтөлбөрийг 2005 онд Гишүүн улс баталсан явдлыг сайшааж байгаа хэдий ч уг хөтөлбөр нь энэхүү Протоколын бүх зүйл заалтыг хамарч чадаагүйд Хороо сэтгэл зовниж байна.

11. Хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор хил дамнуулан худалдахаас хамгаалах үндэсний хөтөлбөрийг Протоколын бусад зүйл заалтаар өргөжүүлэн баяжуулж, үр дүнтэй хэрэгжүүлэх, үйл ажиллагааг нь зохих хэмжээний санхүү болон хүний нөөцөөр дэмжиж өгөхийг Хороо зөвлөж байна.

#### **Зохицуулалт болон үнэлгээ**

12. Хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор хил дамнуулан худалдахаас хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцсан үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг Хорооны зүгээс сайшаан тэмдэглэж байна. Гэвч Зөвлөлийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг системтэйгээр үнэлдэг тогтолцоо байхгүй байгаад Хороо сэтгэл зовниж байна.

13. Үндэсний зөвлөл өөрийн бүрэн эрхээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авах, ингэхдээ зохих санхүү болон хүний нөөцийг хуваарилахыг Хороо Гишүүн улсад зөвлөж байна.

#### **Мэдээлэл түгээх болон сургалт явуулах**

14. Хүүхдийг бэлгийн хүчирхийллээс сэргийлэх, хүнийг хил дамнуулан худалдаалах гэмт хэргээс сэргийлэх талаар олон нийтэд зориулж ном товхимол, сурталчилгааны материал хэвлэх, сургалт хийх зэргээр энэхүү Протоколыг олон нийтэд таниулах ойлгуулах талаар Гишүүн улсын ТББ–уудтай хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээг Хороо сайшаан дэмжиж байна. Гэвч Гишүүн улс энэхүү хүч чармайлтаа системтэй болгож илүү бэхжүүлэх шаардлага байгааг тэмдэглэж байна.

15. Хороо Гишүүн улсад дараах зүйлийг зөвлөж байна:

- (a) Холбогдох бүх мэргэжилтнүүдэд Протоколын заалтын талаар сургалт явуулах, системтэй боловсрол олгох ажлаа үргэлжлүүлэн сайжруулах;
- (b) Сургалтын хөтөлбөр, хүүхдэд тусгайлан зориулсан товхимол зэргийг ашиглан нийт хүн амдаа, тэр дундаа эцэг эх хүүхдүүдэд, Протоколын заалтын талаар мэдээллийг түгээх арга хэмжээгээ сайжруулах;

- (с) Иргэний нийгэмтэй хамтран Протоколын 9(2) дугаар зүйлийн дагуу боловсрол, сургалт зэрэг үйл ажиллагаанд олон нийт тэр дундаа хүүхэд, хохирогч болсон охид хөвүүдийг оролцохыг уриалах зэргээр энэхүү Протоколд заасан гэмт үйлдлийн хор хөнөөл, үүнээс урьдчилан сэргийлж болох арга замын талаар боловсрол олгох, сургалт явуулах зэрэг зохистой бүх аргыг хэрэглэн олон нийт, хүүхдүүдэд мэдээлэл олгох.

#### **Нөөцийн хуваарилалт**

16. Нэмэлт Протоколыг хэрэгжүүлэхэд Гишүүн орон тодорхой хэмжээний төсөв хуваарилсан талаарх мэдээллийг Хороо талархан хүлээн авч байна. Гэвч хуваарилсан төсөв нь хангалттай биш, Протоколын бүх зүйл заалтыг хамарч чадахгүй байгаад Хороо сэтгэл зовнисон хэвээр байна.

17. 2007 онд Конвенцийн 4 дүгээр зүйлийн талаар хийсэн Ерөнхий хэлэлцүүлгийн дараа өгсөн Хорооны зөвлөмжийг харгалзан үзэж, Протоколыг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд үндэсний хэмжээнд болон олон нутгийн хэмжээнд төсвийн хуваарилалтыг нэмэгдүүлэхийг Хороо Гишүүн улсад зөвлөж байна. Хороо Гишүүн улсад мөн дараах зүйлийг зөвлөж байна:

- (а) Орон нутагт урьдчилан сэргийлэх, хамгаалах, хохирогчийн бие махбод болон сэтгэл санааны хохирлыг нөхөн сэргээх, эргэн нийгэмшүүлэх, Протоколд дурдсан гэмт үйлдлийг үйлдсэн этгээдийг яллах зорилго бүхий хөтөлбөр, төслүүдийг боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардлагатай хэмжээний санхүү болон хүний нөөцөөр хангах.
- (б) Гол тайланд өгсөн дүгнэлт зөвлөмжид (CRC/C/MNG/CO/3-4, 18 дугаар заалт, 2010 он 1 сар). тусгасан төсөвлөлтийн арга барилыг нэвтрүүлэх, хүний эрхийн сахин хамгаалах хандлагыг бий болгох.

#### **Бие даасан байгууллагууд**

18. Хүний эрхийн Үндэсний Комисс нь Гишүүн улсын бүх хүүхдүүдэд хүрч ажиллаж чадахгүй байгаад Хороо сэтгэл зовниж байна. Мөн хүүхдүүд өөрсдөө гомдол мэдүүлэх боломжгүй байгаад харамсаж байна.

19. Хүний эрхийн Үндэсний Комисс нь хүүхэд бүрд хүртээмжтэй байх, хүүхэд энэхүү Протоколд заасан болон бусад эрх нь зөрчигдсэн тохиолдолд гомдол мэдүүлэх боломжтой болгох талаар авч буй арга хэмжээгээ сайжруулахыг Хороо Гишүүн улсад зөвлөж байна. Мөн Хүний эрхийн Үндэсний Комисс нь хүүхдээс өөрсдөөс нь гомдол авах бүрэн эрхтэй, чадвартай болох нөхцөл бололцоогоор хангахыг зөвлөж байна.

#### **IV. Хүүхдийг худалдах, биеийг нь үнэлүүлэх, садар самуунд сурталчлахаас урьдчилан сэргийлэх**

20. Гишүүн улсад ядуурал, хүүхдийн бэлгийн хүчирхийлэл өсөж, цаашлаад энэ нь мөнгө олох зорилго бүхий бэлгийн мөлжлөгийг ихэсгэх хүчин зүйл болж байгаа талаар мэдээлэлд Хороо гүнээ сэтгэл зовниж байна.

21. Худалдах, биеийг нь үнэлэх, садар самуунд сурталчлах болон сеск аялал жуулчлалд хүүхэд өртөхөд нөлөөлж буй ядуурал, буурай хөгжил, соёлын хандлага зэрэг

цаад шалтгааныг шийдвэрлэх зорилго бүхий төсөлд санхүү, хүний нөөц хуваарилах зэргээр зохих анхаарлаа үргэлжлүүлэн хандуулахыг Хороо Гишүүн улсад зөвлөж байна. Үүнтэй холбогду олон улс, тэр дундаа хөрш орнуудтайгаа хамтран ажиллах тал дээр авч буй арга хэмжээгээ өргөжүүлэхийг Хороо Гишүүн улсад зөвлөж байна.

## **V. Хориглох болон бусад холбогдох асуудлууд**

### **Одоо буй эрүүгийн болон байцаан шийтгэх хууль тогтоомж**

22. Энэхүү Протоколын 2 болон 3 дугаар зүйлд нийцүүлэн Монгол Улс өөрийн үндэсний хууль тогтоомжид хүүхдийг худалдах, биеийг үнэлүүлэх, садар самуунд сурталчлахыг бүрмөсөн хориглох талаар оруулж өгөөгүйд Хороо сэтгэл зовниж байна. Ялангуяа хүүхдийн биеийг үнэлүүлэх гэмт үйлдлийн тодорхойлолтыг энэхүү Протоколд заасны дагуу хууль тогтоомждоо нарийн заагаагүйгээс үүдэн олон хэргүүд зохих хэмжээнд шийдвэрлэгдэхгүй өнгөрөх тал байгаад сэтгэл зовниж байна.

23. Монгол Улсын эрх зүйн тогтолцоо болон Протоколын хооронд байгаа уялдаагүй, ялгаатай байдлыг олж илрүүлэх арга хэмжээ авах. Ингэхдээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан болон бусад холбогдох олон улсын байгууллагаас тусламж авахыг Хороо Гишүүн улсад зөвлөж байна. Энэхүү Протоколын 2 болон 3 дугаар зүйлийн дагуу хүүхдийг худалдах, биеийг үнэлүүлэх, садар самуунд сурталчлах бүх хэлбэрийг бүрэн хамруулан үндэсний хууль тогтоомждоо нэмэлт өөрчлөлт оруулах талаар бүх арга хэмжээг авахыг Хороо Гишүүн улсад зөвлөж байна.

### **Хуулийн хамрах хүрээ**

24. Монгол Улсын хуулийн үйлчлэх хүрээ нь Протоколын 4-р заалтад нийцэж байгаа байх гэж Хороо үзэхийн зэрэгцээ Протоколд заасан гэмт хэрэг бүрийг хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой мэдээллийг өгөөгүйд Хороо сэтгэл зовниж байна.

25. Протоколын 4-р заалттай бүрэн нийцүүлэн хүн худалдаалах гэмт хэргийн хувьд дотоодын хууль тогтоомж нь өөрийн орны нутаг дэвсгэр биш ч гэсэн үйлчилж байхаар хууль эрх зүйн шинэчлэлт хийхийг Хороо зөвлөж байна.

## **VI. Хохирогч хүүхдийн эрхийг хамгаалах**

Энэхүү Протоколд хориглосон гэмт үйлдлийн хохирогч болсон хүүхдийн эрхийг хамгаалах талаар авсан арга хэмжээ

26. Нэмэлт Протоколд тусгасан гэмт үйлдлийн хохирогч болсон хүүхдүүдийг энэхүү Протоколын 8 дугаар зүйлийн дагуу хохирогч гэдэг утгаар нь зарим үед авч үзэхгүй байгаад сэтгэл зовниж байна. Хороо нь эмэгтэйчүүд, охидыг бэлгийн зорилгоор мөлжих, хил дамнуулан худалдаалах явдлын тоо өссөөр байгаа, буруутай этгээдийг яллан шүүх үйл ажиллагааны түвшин бага байгаа зэрэгт санаа зовниж буйгаа 2008 оны 11 сард илэрхийлсэн Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах конвенцийн хороотой (CE-DAW/C/MNG/CO/7, para. 27 and 28) дуу хоолойгоо нэгтгэж байна. Хохирогч хүүхдийн бие бялдрын болон сэтгэл санааны талаар нөхөн сэргээх, нийгэмшүүлэх үйлчилгээ нэн ховор байгаад санаа зовж буйгаа илэрхийлье.

27. Хороо дараах зүйлүүдийг гишүүн улсад зөвлөж байна.



- (a) Нэмэлт Протоколын 8 дугаар зүйлийн дагуу байцаан шийтгэх бүх үйл явцад хохирогч хүүхдүүдийг хуулиар хамгаалж, тэдний эрх ашгийг дээдлэн, хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавих талаар хуулинд өөрчлөлт оруулах. Ингэхдээ Шүүх үйл явцад Гэмт хэргийн хохирогч болон гэрч хүүхдийн асуудлыг харгалзах талаарх НҮБ-ын зааварчилгааг (ECOSOC Захирамж No. 2005/20) Гишүүн улс мөрдөх ёстой;
- (b) Хохирогч хүүхдийн төлөө ажиллах эрх зүйн төлөөллийг сайжруулах зорилгоор зохих санхүү болон хүний нөөцийг хуваарилах талаар шаардлагатай бүх арга хэмжээг авах;
- (c) Нэмэлт Протоколд тусгасан гэмт үйлдлийн хохирогч болсон хүүхдийг гэмт хэрэгтэн мэт үзэхгүй байж, шийтгэхгүй байх, тэднийг нийгмээс ялгаварлан дорд үзэхгүй байхыг баталгаажуулах;
- (d) Нэмэлт Протоколын 9 (3) дүгээр зүйлтэй уялдуулан охид, хөвгүүд ялгалгүй хохирогч бүх хүүхдийг бие бялдар, сэтгэл санааны талаар бүрэн нөхөн сэргээх, нийгэмшүүлэхэд чиглэсэн үйлчилгээг хангалттай байлгахад анхаарах;

28. Хүүхдийг худалдах, биеийг үнэлүүлэх, садар самуунд сурталчлах үйл явц болон хохирогч хүүхэд цагдаагийн байгууллагаар дамжин хууль сахиулах байгууллагад бүртгэгдсэнээс эхлэн хүүхдийг нөхөн сэргээх хүртэл үйл ажиллагаанд судалгаа шинжилгээ хийж хуулийн болон нийгмийн үйлчилгээний тогтолцоонд ямар саад бэрхшээл байгааг илрүүлэх, судалгааны дүгнэлтэд үндэслэн үр дүнтэй цогц бодлого боловсруулж хэрэгжүүлэхийг Хороо зөвлөж байна.

29. Хохирогч хүүхдүүдэд туслах хүүхдийн яаралтай дуудлагын утасны тоо болон хүртээмжийг нэмэгдүүлэхийг Хороо Гишүүн улсад зөвлөж байна. Үүнтэй холбогдуулан, хүүхэд энэхүү утасны талаар мэдээлэлтэй байж, эдгээр утас нь хүүхэд уруу чиглэсэн байх, ТББ, цагдаа мөн түүнчлэн эрүүл мэнд нийгмийн ажилтантай хамтран ажиллах талаар Гишүүн улсыг хичээл зүтгэл гаргахыг Хорооноос зөвлөж байна.

### **Хохирогчдод нөхөн сэргээх болон эргэн нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх**

30. Протоколд тусгасан гэмт үйлдлийн хохирогч хүүхэд зэрэг хамгийн эмзэг хүүхдүүдэд халамж, хамгаалал дэмжлэг үзүүлэх тал дээр иргэний нийгмийн хийсэн бахархууштай үйл ажиллагааг Хороо сайшаан хүлээн авч байна. Гэвч аймаг, орон нутгийн түвшинд хохирогч хүүхдийн эрх болон хэрэгцээг илүү цогц, зохистой байдлаар шийдвэрлэдэг системтэй, зохицуулалт бүхий механизм байхгүй байгаад сэтгэл зовниж байна.

31. Хороо дараах зүйлүүдийг Гишүүн улсад зөвлөж байна.

- (a) Протоколд хориглосон гэмт үйлдлийн хохирогч болсон хүүхдүүдтэй ажилладаг хүмүүсийг энэхүү протоколын 8 (4) дугаар зүйлд заасны дагуу зохих сургалт, тэр дундаа эрх зүй сэтгэцийн эрүүл мэндийн сургалтад хамруулах арга хэмжээг авах;
- (b) Протоколд заасан гэмт үйлдлийн хохирогч болсон хүүхэд бүр ялгаварлалгүйгээр энэхүү Протоколын 9(4) дугаар зүйлийн дагуу гэмт этгээдээр хохирлоо нөхөн барагдуулах зэрэг эрх зүйн тусламж хүртэх боломжоор хангах.

## **VII. Олон улсын хамтын ажиллагаа болон тусламж**

### **Олон талт, бүс нутгийн болон хоёр талд гэрээ хэлэлцээр**

32. Худалдах, биеийг үнэлүүлэх, садар самуунд сурталчлах болон сеск аялал жуулчлал зэрэгт өртөхөд нөлөөлж буй ядуурал буурай хөгжил соёлын хандлага зэрэг цаад шалтгааныг шийдвэрлэхийн тулд Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагууд болон хөтөлбөр, Иргэний нийгэм болон хоёр талт хамтыг ажиллагааг үргэлжлүүлэн сайжруулахыг Хороо Гишүүн улсад уриалж байна.

### **Хууль сахиулах**

33. Хүүхдийг худалдах, биеийг үнэлүүлэх, садар самуунд сурталчлахаас сэргийлэх, үүнтэй тэмцэх зорилгоор шүүх, цагдаа, хохирогчид туслах гэх мэт чиглэлээр олон улс болон бүс нутгийн хэмжээнд бусад улсуудтай хамтран ажилласан талаар Конвенцийн дараагийн тайлан илтгэлд илүү нарийвчилсан мэдээлэл оруулахыг уриалж байна.

## **VIII. Зөвлөмжийг түгээх болон хэрэгжүүлэх**

### **Зөвлөмжийг хэрэгжүүлэх**

34. Энэхүү зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авах, тэр дундаа зөвлөмж нь холбогдох яам, тамгын газар, Улсын Их Хурал, аймаг нийслэлийн Засаг дарга, Иргэдийн хурлын дарга нарт хүрсэн, тэдний үйл ажиллагаанд тусгалаа олсон байх бүх арга хэмжээг авахыг Гишүүн улсад Хороо зөвлөж байна.

### **Түгээх**

35. Олон нийтийн дунд Нэмэлт Протокол болон түүний хэрэгжилт, хяналтын талаар мэтгэлцээн өрнүүлж мэдлэг дээшлүүлэх үүднээс Гишүүн улсын гурав дөрөвдүгээр тайлан, бичгээр өгсөн хариулт болон дүгнэлт зөвлөмжийг иргэний нийгмийн байгууллага, хүүхэд залуучуудын бүлэг, хэвлэл мэдээлэл, мэргэжлийн хүмүүс болон хүүхдүүд, олон нийтэд өргөн хүрээнд хүртээмжтэй болгох, ингэхдээ интернетийг мөн ашиглахыг зөвлөж байна.

## **IX. Дараагийн тайлан**

36. Конвенцийн 44 дүгээр зүйлийн дагуу, Хүүхдийн Эрхийн тухай Конвенцийн хэрэгжилтийн талаар тав дахь тайлан илтгэлийг өгөхдөө 8 дугаар зүйлийн 2 дугаар заалтын дагуу энэхүү Нэмэлт Протоколын хэрэгжилтийн талаарх мэдээллийг нэгтгэж оруулахыг Гишүүн улсаас хүсэж байна.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

**ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН  
БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ,  
ХҮНЛЭГ БУСААР БҮЮУ  
ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ  
ДОРМЖЛОН ХАРЬЦАЖ  
ШИЙТГЭХИЙН ЭСРЭГ  
КОНВЕНЦ**

## **7.1 ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР БУЮУ ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРОМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦИЙН ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН АНХДУГААР ИЛТГЭЛ (2009 ОН)**

### **Оршил**

1. Энэхүү илтгэлийг 2000 оны 11 дүгээр сарын 2-нд Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталсан “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх”-ийн эсрэг 1984 оны НҮБ-ын конвенцийн 19 дүгээр зүйлийг үндэслэн боловсруулсан болно.

2. Энэхүү илтгэл нь 2000–2007 оныг хамруулсан болно.

3. Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам илтгэлийг Улсын Ерөнхий прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газартай хамтран бэлтгэв.

### **I. Ерөнхий мэдээлэл**

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд хүний эрх, эрх чөлөөг төрийн бодлогын цөм болгон дэлхий дахины ардчилсан чиг хандлагад нийцүүлэн тунхагласан билээ.

Шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш Монгол Улсад хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангах, төрөөс иргэдийн өмнө хүлээх хариуцлагыг өндөржүүлэх, хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын тогтолцоог боловсронгуй болгоход чиглэсэн шат дараалсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлээ.

Хүний эрхийг хязгаарлах, хүнийг нэгжих, баривчлах үндэслэл журам, түүнд хяналт тавих, хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндсийг боловсронгуй болгох, бусдын эрх, эрх чөлөөг хүндэтгэж, нийгмийн хэв журмыг сахих зарчмыг мөрдүүлэх чиглэлээр нарийвчилсан зохицуулалт хийх зорилгоор Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хууль, Шүүхийн тухай хууль, Прокурорын байгууллагын тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Өмгөөллийн тухай хуулийг 2002 онд тус тус шинэчлэн боловсруулж, баталлаа.

Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” хэмээн заасан.

Энэ нь Монгол Улсын нэгдэн орсон хийгээд хүний эрхийн талаар байгуулсан олон талт болон 2 талт аливаа гэрээ, тэр дундаа “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх”-ийн эсрэг Конвенцийн (цаашид Конвенц гэх) Монголын эрх зүйн системд эзлэх байр суурийг

илэрхийлэх бөгөөд Монгол Улсад хүний эрх, эрх чөлөөний асуудал нь дотоодын хууль тогтоомж болон манай улсын нэгдэн орсон олон улсын гэрээний дагуу зохицуулагдаж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж; 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэж тус тус заасан. Мөн Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” хэмээн хүний эрхийн талаарх төрийн дотоод чиг үүргийг заасан.

2002 онд шинэчлэн баталсан Шүүхийн тухай хуульд “Шүүх нь хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны баталгаа мөн”, “Шүүгч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ хараат бус байж гагцхүү Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хуульд захирагдана” гэж заасан. Шинээр боловсруулсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг УИХ-аас 2002 онд баталсан. Энэ хуулийн үндсэн зорилго нь засаг захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус ажиллагаа, дур зоргоор аашлах явдлаас хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг нь сэргээн тогтоох, эрх зүйн шударга дэг журмыг дэмжих явдал юм. Энэ хууль батлагдсанаар Монгол Улсад Захиргааны хэргийн шүүх байгуулагдан 2004 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Прокурорын байгууллагын тухай 2002 оны хуульд зааснаар прокурорын байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн үүрэг гүйцэтгэж, үйл ажиллагаагаа төрийн нэрийн өмнөөс явуулдаг, бие даасан, хараат бус, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага юм.

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад хэргийн холбогдогч, сэжигтэнг ямар нэг хэлбэрээр дарамтлах, харгис хэрцгий, хүнлэг бусаар хандах явдал гарч байсан боловч өмнөх хуулиудад зааснаар цагдаагийн байгууллагын дээрх ажилтнуудын талаарх гомдол, мэдээллийг цагдаагийн байгууллага өөрөө шалгадаг байсан тул эдгээр асуудал үнэн зөв бодитой шийдвэрлэгдэхгүй дарагдах тохиолдол гардаг байсан.

Энэ байдлыг таслан зогсоож, хүний эрхийг хангах, хүнлэг бус хэрцгий харьцах явдлыг арилгах үүднээс 2002 онд батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар цагдаа, шүүх, прокурорын ажилтнуудаас хүнлэг бус хэрцгий хандсан талаарх гомдол, мэдээлэл, хэргийг Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба шалгаж байхаар шинэчлэн хуульчилж, Монгол Улсын Ерөнхий Прокурорын дэргэд Мөрдөн байцаах алба байгуулан ажиллуулж байна. Тус алба нь Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хууль болон УИХ-ын 2002 оны 47 дугаар тогтоол, Засгийн газрын 2002 оны 179 дүгээр тогтоолын дагуу 2002 оны 9 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн зохион байгуулагдаж Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т заасан цагдаагийн байгууллагын ажилтан, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн үйлдсэн

гэмт хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байна.

Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн дагуу Цагдан хорих байр нь цагдаагийн байгууллагын харьяанд байсан бол 2002 оны эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хийгдсэн багц хуулиар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяанд шилжсэн болно. Энэ нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, гүйцэтгэх ажил эрхэлдэг цагдаагийн байгууллагаас цагдан хорих байрыг ангид байлгаж хүний эрхийг хамгаалах, тэр хэмжээгээр эрүүдэн шүүх, хүнлэг бусаар харьцах, элдэв дарамт шахалтаас сэргийлэх үүднээс хийгдсэн эрх зүйн хамгаалалт юм.

Хүний эрхийг хангахад чиглэсэн бие даасан үйл ажиллагаа явуулдаг Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль 2000 оны 12 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан нь хүний эрхийг хангах талаар хийсэн томоохон шинэтгэлийн нэг юм. Энэхүү хууль батлагдаж УИХ-аас 2001 оны 2 дугаар сард Комиссын гишүүдийг томилсноор Хүний эрхийн Үндэсний Комисс (цаашид ХЭҮК гэх) үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. ХЭҮК нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхиүлэн дэмжих чиг үүрэг бүхий хараат бус байгууллага юм. Уг хуульд заасны дагуу Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг нь аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн зөрчсөн гэж үзвэл Монгол Улсын иргэн дангаараа буюу хамтарч хуульд заасны дагуу ХЭҮК-т гомдол гаргах эрхтэй болсон.

Энэ байгууллага нь хүний эрхийн аливаа асуудлаар санал гаргах, бусад этгээдэд шаардлага, зөвлөмж хүргүүлэх бүрэн эрхийг эдэлдэг. Өөрөөр хэлбэл онц байдлын үед ч түүний бүрэн эрх хэрэгжих юм гэдгийг мэдээлж байна. Хүний эрхийн орон нутгийн болон үндэсний хэмжээний байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, хөгжүүлэх, төлөвшүүлэн бэхжүүлэх, хүний эрхийг хангах талаар шат дараатай, цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийг (цаашид Үндэсний хөтөлбөр гэх) УИХ-ын 2003 оны 41 дүгээр тогтоолоор баталсан.

Энэхүү хөтөлбөр нь төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангах баталгаа-механизмыг бүрдүүлэх, уул эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг тууштай, үр нөлөөтэй хэрэгжүүлэх үйлсэд засаг төрийн байгууллага, албан тушаалтны санаачилга, хариуцлагыг дээшлүүлэн, иргэний нийгэм, юуны өмнө нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн бус байгууллага, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хувийн хэвшлийн оролцоог өргөтгөн, үр нөлөөг нь сайжруулах, иргэдийн санаачилгыг өрнүүлэх чиглэл, арга замыг тодорхойлсон баримт бичиг юм.

Тус хөтөлбөрт заасны дагуу Үндэсний хөтөлбөрийн биелэлтийг зохион байгуулах ажлыг Засгийн газар бүхэлд нь хариуцах бөгөөд өдөр тутмын ажлыг Засгийн газрын өмнөөс Үндэсний хөтөлбөрийн хороо эрхлэн гүйцэтгэнэ. Үндэсний хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, эрх хэмжээ, санхүүжих журам зэргийг Засгийн газрын 2005 оны 167 дугаар тогтоолоор тогтоосон байна.

Монгол Улсын иргэд Үндсэн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон бусад хуулийн дагуу дээр дурдсан төрийн байгууллагууд ХЭҮК-т өргөдөл, гомдол, тэр дундаа

**ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР БҮЮУ  
ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦ**

эрүүдэн шүүх, харгис, хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцсан талаар гомдол гаргах эрхтэй.

Хэдийгээр ийнхүү шат дараатай арга хэмжээнүүд авагдаж байгаа боловч хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж байгаа этгээдтэй хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, хорих байрны хянагч нар зүй бусаар харьцах, зодох, эрүүл мэндэд нь хохирол, гэмтэл учруулах явдал сүүлийн жилүүдэд нэг бус удаа гарсан нь иргэдийн гомдол, мэдээлэл, хүний эрхийн болон хуулийн байгууллагын хяналт шалгалтын явцад тогтоогдож байна.

Цагдаагийн албан хаагчдаас иргэдтэй зүй бус харьцсан тухай өргөдөл, гомдлоор эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан байдлын тухай Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албанаас дараах судалгааг гаргасан байна.

Үүнд:

2002 оны 9 сараас 2007 он

Он	Зүйл анги	Хэргийн тоо	Холбог-догчийн тоо	Хэрэгсэхгүй болгосон хэргийн тоо	Түдгэл-зүүлсэн хэргийн тоо	Шүүхэд шилжүүлсэн хэргийн тоо	Нийт хэргийн тоо оноор
2002 он 9 сар	251						
	253						
	256						
2003	251	5	6	2	0	2	
	253	9	11	3	1	5	14
	256	0					
2004	251	2	7			2	
	253	14	23	5		5	16
	256	0					
2005	251	5	7	1	1	2	
	253	14	23	4		6	19
	256	0					
2006	251	3	5	2			
	253	1	2				4
	256	0					

ДОЛООДУГААР БҮЛЭГ

Он	Зүйл анги	Хэргийн тоо	Холбог-догчийн тоо	Хэрэгсэхгүй болгосон хэргийн тоо	Түдгэл-зүүлсэн хэргийн тоо	Шүүхэд шилжүүлсэн хэргийн тоо	Нийт хэргийн тоо оноор
2007	251	5	11			3	20
	253	14	10	5	1	2	
	256	1	4				
Бүгд	251	21	36	5	1	9	73
	253	52	69	17	2	18	
	256	1	4				

II. Конвенцийн заалт бүрийн хэрэгжилт

1 дүгээр зүйл

Энэхүү Конвенцийн 1 дүгээр зүйлд Конвенцийн зорилготой уялдуулан “эрүүдэн шүүх” гэж юуг хэлэх вэ гэдгийг тодорхойлсон бөгөөд үүнд хамаарах аливаа үйлдэл, үйл ажиллагааг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид хориглож, шударга ёс, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн авч үздэг болно. Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.” хэмээн заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2-т “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж, 16 дугаар зүйлийн 13-т Монгол Улсын иргэн халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй” хэмээн заасан билээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 10.4-т “Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй.” гэж заасан. УИХ-аас баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаар илүү дэлгэрэнгүй тусгаж өгсөн. Энэ хэргийн улмаас хүний бие махбодод хүндэвтэр, хүнд гэмтэл, их хэмжээний хохирол учирсан бол хүнд гэмт хэрэгт тооцож ял онохоор заасан.

Эрүүгийн хуульд энэхүү нэмэлт өөрчлөлтийг оруулахаас өмнө ч “эрүүдэн шүүх” гэмт хэргийн талаар уг хуульд тусгаж, хэд хэдэн зүйл заалтын дагуу хүний сэтгэл санаа болон бие махбодид хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, тарчилган



зовоох, тохуурхан даажигнах, хуурч мэхлэх зэрэг хууль бус үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэж байсан. Тухайлбал, 248 /илт гэм буруугүй хүнийг сэжигтнээр тооцох, яллагдагчаар татах, ял шийтгэх/; 249 /Хүнийг хууль бусаар баривчлах/; 250/ Шүүхээс хууль бус шийдвэр гаргах/; 251 /Мэдүүлэг өгөхийг албадах/; 253/Нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлэх/; 256/ Гэрч, хохирогчоор худал мэдүүлэг өгүүлэх, шинжээчээр худал дүгнэлт гаргуулах, орчуулагчаар худал орчуулуулах, хэлмэрчээр худал хэлмэрчлүүлэх/; 263 /Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах/; 264 /Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх/ зэрэг болно.

## **2 дугаар зүйл**

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүдэн шүүх аливаа үйлдлийг гаргахгүй байх, түүнээс урьдчилан сэргийлэх, гарсан нөхцөлд хариуцлага тооцох, түүнийг арилгах, засч залруулах талаар хуульд тусгайлан заасан болно. 2007 онд Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд эрүүдэн шүүх аливаа үйлдлийг урьдчилан сэргийлэх, тийм нөхцөл байдалд хүргэхгүй байх үүднээс тодорхой өөрчлөлтүүд орсон. Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж бүр Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх, хуулийн биелэлтийг зохион байгуулж хангах үүрэгтэй байхаар тодорхойлсон. Иймээс хууль нэгэнт батлагдан гарсан нөхцөлд заавал биелэгдэж байх үр дагавартай тул бид энэхүү конвенцийн дагуу хэрэгжүүлж буй арга хэмжээг хуулийн холбогдох заалтаар тухайлан авч үзэж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд 16.13–т “Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ”, 16.14–т “Монгол Улсын иргэн өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно” гэж заасан байна. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 10.5–д “Сэжигтнийг баривчлах үед түүнд баривчилсан шалтгаан, үндэслэлийг мэдэгдэж, өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, шүүхэд гомдол гаргах, өөрийгөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг сануулна” гэж заасан. Түүнчлэн уг хуулийн 16 дугаар зүйлд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс гэм буруугүй болохыг өөрөөр нь нотлуулахаар шаардах эрхгүй болохыг заасан ба шүүгдэгчийг өөрийнхөө эсрэг болон гэр бүлийн гишүүн эцэг эх, үр хүүхдээс нь түүний эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглосон. Хэрвээ сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь өөрөө мэдүүлэг өгөх хүсэлт гаргавал түүнд мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэйг нь тайлбарласны эцэст мэдүүлэг авна.

Түүнчлэн уг хуулийн 35.2–д заасны дагуу сэжигтэн, яллагдагч нь мэдүүлэг өгөх, мэдүүлэг өгөхөөс татгалзах, өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгч авах, өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын үйл ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах, хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас учирсан хохирлоо нөхөн төлүүлэх, хэрэг бүртгэгч мөрдөн байцаагч, прокурор, орчуулагч, шинжээчийг

татгалзан гаргах тухай хүсэлт гаргах, шинжээч томилсон тогтоол болон шинжээчийн дүгнэлттэй танилцах зэрэг эрхүүдийг тусгайлан зохицуулж өгсөн. Байцаан шийтгэх ажиллагааны явцад уг ажиллагаанд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, хууль зүйн туслалцаа үзүүлэх үүрэгтэй өмгөөлөгчийн эрх үүргийг дээрх хуулиар зохицуулж өгсөн. Уг хуулийн 38.3–д заасны дагуу хойшлуулшгүй ажиллагаа явуулж эхэлсэн, эсхүл гэмт хэрэгт сэжигтнээр тооцсон үеэс эхлэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцдог ба сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч нь өмгөөлөгчөө өөрөө сонгох эрхтэй.

Сэжигтнийг зөвхөн шүүхийн шийдвэрээр баривчлах буюу цагдан хорьж болох ба баривчлах цагдан хорих журмыг ЭБШ хуулийн наймдугаар бүлэг, 68–70 дугаар зүйлүүдэд тусгайлан заасан. Уг хуульд хэрэг бүртгэгч мөрдөн байцаагч нь сэжигтнийг баривчилсан болон хаана байгааг 24 цагийн дотор түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, төрөл, садангийн хүн, эсхүл өмгөөлөгчид нь мэдэгдэх, эсхүл өөрөө мэдэгдэх боломжийг баривчлагдсан этгээдэд олгохоор тусгасан байна.

2. Монгол Улсын Шүүхийн тухай хуульд “Шүүх нь хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны баталгаа мөн”; “Шүүгч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ хараат бус байж, гагцхүү Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хуульд захирагдана.” гэж заасан.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 7 дугаар зүйлд “Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төр, алдар хүндийг нь гутаах зорилго, хэлбэр агуулж болохгүй” гэж заасан. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны эрх ашиг сонирхлыг хүндэтгэх, шуурхай, энэрэнгүй байх зарчимд үндэслэнэ” хэмээн заасан бөгөөд уг хуульд эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийтгэх тогтоол гүйцэтгэх ажиллагаа, баривчлах байр, хорих анги, гяндангийн нөхцөл, журам, ялтны эрх үүрэг, ялтны хөдөлмөр, хөдөлмөрийн нөхцөл, ялтныг харуул хамгаалалтгүй ажиллуулах, ялтны дунд зохиох хүмүүжлийн ажлын хэлбэр, зохион байгуулалт, ялтныг урамшуулах, ялтны ахуй нөхцлийг тодорхойлон заасан болно. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд 2007 оны 8 дугаар сарын 3–ны өдрийн хуулиар “ялтан ял эдлүүлэх байгууллагын зүгээс хүнлэг харьцахыг шаардах, хувийн аюулгүй байдлаа хамгаалуулах эрхтэй байхаар нэмэлт оруулсан байна.

Сэжигтэн яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд “Албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэхэд хууль дээдлэх, хүнлэг ёс, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх зарчмыг баримтална. Албадан саатуулагдсан, цагдан хоригдсон этгээдэд эрүү шүүлт тулгах, эсхүл бусад арга хэрэглэн түүний бие махбодыг тарчлаан зовоох буюу сэтгэл санааны дарамтад оруулахыг хориглоно” хэмээн заасан. Энэхүү хуульд цагдан хорих шийдвэрийг биелүүлэх байгууллага, түүний ажилтны эрх, үүрэг, цагдан хорих нөхцөл, журам; хоригдсон этгээдийн эрх, үүрэг, түүнийг хэрэгжүүлэх журмыг тусгасан.

Сэжигтэн яллагдагчтай зүй бусаар харьцахаас сэргийлэх зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2005 оны 01 дүгээр сарын 28–ны өдрийн 14 дүгээр тушаалаар “Цагдан хорих байрны дотоод журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Эрүүл мэндийн сайдын 2005 оны 3 дугаар сарын 25–ны өдрийн хамтарсан 37/64 дүгээр

тушаалаар “Цагдан хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, түүнийг эрүүл мэндийн байгууллагад эмчлэх, цагдан хорих байранд эмнэлгийн мэргэжилтэн ирж үйлчлэх журам”-ыг тус тус батлан мөрдөж байна.

Үүнээс гадна сэжигтэн, яллагдагч, ялантай албан үүргийн дагуу харьцдаг байгууллагын ажилтнууд нь хуулийг дээдэлж, чанд сахин биелүүлж, энэрэнгүй шударга байж, бусдыг доромжлох, нэр төрийг нь гутаах, басамжлах, сүрдүүлэх, ялгаварлан хандах, хүнд суртал, бүдүүлэг зан авир гаргах явдлыг хориглох зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2002 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 205 дугаар тушаалаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын сахилгын дүрэм”-ийг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм”-ийг тус тус батлан гаргаж, мөрдөн ажиллаж байна. “Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх” тухай хуулиар согтуурсны улмаас өөрийн үйлдлийг удирдан жолоодох чадваргүй этгээдийг осолдох, бусдын хууль бус үйлдэлд өртөж хохирохоос хамгаалах, гэмт хэрэг үйлдэх, захиргааны зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор явуулж байгаа эрүүлжүүлэх үйл ажиллагааг зохицуулсан нь ач холбогдолтой болсон. Урьд нь Цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан журмаар зохицуулагдаж байсан албадан эрүүлжүүлэх харилцааг хуульчилсан нь тодорхой нэг албан тушаалтны шийдвэрээр батлагддаг журмыг үндэслэн хүний эрхийг хязгаарлах явдлыг зогсоож, согтуурсны улмаас биеэ авч явж чадахгүй болсон хүн эрүү шүүлтэд өртөх явдлыг гаргуулахгүй байх, хүний эрхийг хамгаалах нэг баталгаа болсон.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд “Онц болон Дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө.” гэж хүний салшгүй эрхийг хуульчлан хамгаалсан.

Түүнчлэн Монгол Улсын Дайны байдлын тухай, Дайн бүхий байдлын тухай, Онц байдлын тухай зэрэг хуульд тухайн нөхцөлд авах арга хэмжээний талаар тодорхой тусгасан. Онц байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлд “Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 5 дахь заалт, 16 дугаар зүйлд заасны дагуу хүний эрх, эрх чөлөөний хязгаарлалт нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд ч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон Үндсэн хуулийн заалтыг үл хөндөнө” гэжээ. 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт бүлэг хүмүүсийн хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас нийтийн эмх замбараагүй байдал үүсч, хууль сахиулах байгууллагын ажилтнуудад халдан, амь насанд нь заналхийлж, эд хөрөнгө устгах, галдан шатаах үйл ажиллагаа даамжирч, нийтийн эмх замбараагүй байдал бий болсон тул энэхүү онцгой нөхцөл, үр дагаврыг арилгах, хүн ам нийгмийн амьдралыг хэвийн болгох зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгч 2008 оны 7 дугаар сарын 1-ны өдөр 194 дүгээр захирамж гаргаж Үндсэн хуулийн 33.1.12-т заасан бүрэн эрхийнхээ дагуу онц байдал тогтоосон ба ийнхүү онц байдал зарласан тухай мэдэгдэж Монгол Улсын Засгийн газрыг

төлөөлж Гадаад хэргийн сайд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад ноот бичгийг илгээсэн билээ.

Уг захирамжид заасны дагуу онц байдлыг зарласан хугацаанд улсын онц чухал болон хүн амын амьжиргааны хангамжийн объектуудыг хүч нэмэгдүүлэн хамгаалах, Улаанбаатар хотын төвийн хэсэгт тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, тэдгээрт үзлэг хийх зэрэг тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэглэхээр заасан бөгөөд уг арга хэмжээнүүдийг авах явцад Монгол Улсын Үндсэн хууль, Онц байдлын тухай хуульд заасан хүний халдашгүй эрх, эрүүдэн шүүхийн эсрэг заалтууд сахин мөрдөгдсөн.

Дайны байдлын тухай хуульд хүний эрх, эрх чөлөөний баталгааны талаар тусгайлан заасан ба хуулийн 26 дугаар зүйлд “Дайны байдлын үеийн үндсэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлахыг хориглоно. Монгол Улсын нутаг дэвсгэрийн зарим хэсэгт дайны байдал зарлавал энэ нь нутаг дэвсгэрийн бусад хэсгийн төрийн захиргааны байгуулал, хүний эрх, эрх чөлөөг үл хөндөнө” гэж заасан. Ийнхүү Монгол улсын хууль тогтоомжид хүний жам ёсны эрхийг хэн ч, ямар ч нөхцөлд хөндөхийг хориглосон байна.

### **3 дугаар зүйл**

1. Монгол Улсын Үндсэн хуулийн 15 дугаар зүйлд Монгол Улсын иргэнийг харьяатаас хасах, эх орноосоо хөөх, өөр улсад шилжүүлэн өгөхийг хориглоно гэж заасан.

Эрүүгийн хуулийн 15 дугаар зүйлд:

1) Монгол Улсын иргэнийг эрүүгийн хэрэгт мөрдүүлэх буюу эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр гадаад улсад шилжүүлж өгөхгүй;

2) Монгол Улсын хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнийг эрүүгийн хариуцлага хүлээлгэх буюу ял эдлүүлэхээр Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу гадаад улсад шилжүүлж болно гэж заасан байна.

Мөн Үндсэн хуулийн 18 дугаар зүйлд “Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэний эрх, үүргийг Монгол Улсын хууль, уул иргэнийг харьяалсан улстай байгуулсан гэрээгээр тогтооно. Монгол Улс олон улсын гэрээгээр гадаадын иргэний эрх, үүргийг тодорхойлохдоо уул иргэнийг харьяалсан улстай энэ талаар харилцан адил байх зарчим баримтална. Монгол Улс нутаг дэвсгэртээ байгаа харьяалалгүй хүний эрх, үүргийг өөрийн хуулиар тогтооно.” гэж заасан.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 46 дугаар бүлэгт гадаад улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн буюу шийтгэгдсэн гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнийг шилжүүлэн өгөх, 47 дугаар бүлэгт Монгол Улсын шүүхээр хорих ял шийтгүүлсэн этгээдийг харьяат улсад нь шилжүүлэн өгөх талаар зохицуулсан бөгөөд эдгээр асуудлыг олон улсын гэрээ, хэлэлцээрт заасны дагуу шийдвэрлэнэ гэсэн байна. Монгол Улсын байгуулсан “Иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай” гэрээнүүдээс 12-т нь гэмт этгээдийг шилжүүлэн өгөх талаар тусгасан байдаг бөгөөд Монгол Улс нь БНХАУ, БНСУ, БНЭУ-тай “Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай” гэрээ, БНКанаду, БНСУ-тай “Ялтан шилжүүлэх тухай” гэрээ тус тус байгуулсан. Эрүүгийн

байцаан шийтгэх хуулийн 46, 47 дугаар бүлгүүдэд шилжүүлэн өгөхөөс татгалзах үндэслэлүүдийг тусгасан боловч “эрүүдэн шүүх аюул тулгарна гэж үзэх хангалттай үндэслэл” байх тохиолдлыг тусгайлан заагаагүй болно. БНСУ–тай байгуулсан “Ялтан шилжүүлэх өгөх тухай” гэрээний 4 дүгээр зүйлийн “ё”–д “тухайн ялтан болон түүний хууль ёсны этгээд өөрийг нь шилжүүлэн өгөхийг зөвшөөрсөн байх”–аар, “ял ногдуулсан болон хүлээн авагч талууд ялтныг шилжүүлэхийг харилцан зөвшөөрсөн байх”–аар тус тус заасан.

БНСУ–тай байгуулсан Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай гэрээний 3 дугаар зүйлд “гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай хүсэлт нь эрэн сурвалжлагдаж буй этгээдийг арьс өнгө, шашин шүтлэг, иргэний харьяалал, хүйс эсхүл улс төрийн үзэл бодлоор нь ял шийтгэх гэж байгаа, эсхүл шүүн таслах ажиллагааны үеэр дээрх шалтгаанаар хохироох бодитой үндэслэлтэй гэж хүсэлт хүлээн авагч тал үзсэн”, 4 дүгээр зүйлд “онцгой тохиолдолд хүсэлт хүлээн авагч тал тухайн гэмт хэргийн хүнд, хөнгөн болон хүсэлт гаргагч талын ашиг сонирхлыг харгалзан үзэхийн хамтаар, эрэн сурвалжилж буй тухайн этгээдийн хувийн нөхцөл байдлаас шалтгаалан ийнхүү шилжүүлэн өгөх нь хүмүүнлэгийн үүднээс нийцэхгүй байна хэмээн үзвэл” гэмт этгээдийг шилжүүлэн өгөхөөс татгалзах эрхтэй байхаар тус тус заасан нь хүнлэг бус, нэр төрийг нь доромжлон харьцахаас сэргийлсэн арга хэмжээ болсон.

2. Монгол Улсаас гадаадын иргэнийг албадан гаргах, буцаах асуудлыг 1993 оны Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулдаг. Тус хуулийн 30 дугаар зүйлд гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах тухай шийдвэрийг Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны саналыг үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн сайд гаргана. Албадан гаргах тухай шийдвэрийг Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба, хил хамгаалах болон цагдаагийн байгууллагатай хамтран гүйцэтгэж байна. 2000–2008 оны байдлаар нийт 11 улсын харьяат 3713 гадаадын иргэнийг албадан гаргах шийдвэрийг холбогдох байгууллагуудтай хамтран гүйцэтгэсэн байна. Энэ хугацаанд албадан гаргах шийдвэрийг гүйцэтгээгүй тохиолдол гараагүй бөгөөд албадан гаргах явцад хүний эрх хохирсон, эсхүл эрүүдэн шүүх аюул тулгарах үндэслэлээр гадаадын иргэнийг албадан гаргахаас татгалзсан тохиолдол гараагүй байна.

#### **4 дүгээр зүйл**

Конвенцийн 1 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг үйлдэхэд хариуцлага ноогдуулах заалт Монгол Улсын Эрүүгийн хуульд тусгагдсан. Тухайлбал, дараах төрлийн гэмт хэргүүдэд ял ноогдуулахаар заасан:

- 1) Илт гэм буруугүй хүнийг сэжигтнээр тооцох, яллагдагчаар татах, ял шийтгэх (248–р зүйл) (ялын дээд хэмжээ – арван жил хүртэл хугацаагаар хорих);
- 2) Хүнийг хууль бусаар баривчлах (249 дүгээр зүйл) (ялын дээд хэмжээ – таван жил хүртэл хугацаагаар хорих);
- 3) Шүүхээс хууль бус шийдвэр гаргах (250 дугаар зүйл) (ялын дээд хэмжээ – арван жил хүртэл хугацаагаар хорих);
- 4) Эрүү шүүлт тулгах (251 дүгээр зүйл) (ялын дээд хэмжээ – арван таван жил

- хүртэл хугацаагаар хорих);
- 5) Нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлэх (253 дугаар зүйл) (ялын дээд хэмжээ – таван жил хүртэл хугацаагаар хорих);
  - 6) Гэрч, хохирогчоор худал мэдүүлэг өгүүлэх, шинжээчээр худал дүгнэлт гаргуулах, орчуулагчаар худал орчуулуулах, хэлмэрчээр худал хэлмэрчлүүлэх (256 дугаар зүйл) (ялын дээд хэмжээ – найман жил хүртэл хугацаагаар хорих)
  - 7) Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаар урвуулан ашиглах (263 дугаар зүйл), төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах (265 дугаар зүйл), төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх (264 дүгээр зүйл), төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх (266 дугаар зүйл) (ялын дээд хэмжээ – таван жил хүртэл хорих).

Эрүүгийн хуулийн 56 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт ял хүндрүүлэх нөхцөл байдлыг заасан бөгөөд түүн дотор “гэмт хэргийг онц харгис хэрцгий аргаар буюу хохирогчийг тохуурхан даажигнаж үйлдсэн”, “... албан тушаалын болон өөр байдлаар эрхшээлдээ байсан хүний эсрэг гэмт хэрэг үйлдсэн” гэх зэрэг тохиолдлууд орсон.

Эрүүгийн хуулийн 34 дүгээр зүйлд заасны дагуу гэмт хэрэг санаатай үйлдэхэд хоёр буюу түүнээс дээш этгээд нэгдсэнийг хамтран оролцох гэнэ. Мөн хуулийн 35 дугаар зүйлд гэмт хэрэгт хамтран оролцогчдыг захиалагч, зохион байгуулагч, хатгагч, хамжигч хэмээн тус тус ялган тодорхойлж өгсөн. Шүүх гэмт хэрэгт хамтран оролцогчид хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг сонгон хэрэглэхдээ оролцогч бүрийн гэмт хэрэг үйлдэхэд гүйцэтгэсэн үүрэг, үйлдлийн шинж чанар, хэр хэмжээг харгалзан тогтооно (Эрүүгийн хуулийн 37 дугаар зүйл). Эрүүгийн хуулийн 30 дугаар зүйлд зааснаар гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэх болон завдахыг төгсөөгүй гэмт хэрэг гэнэ. Төгсөөгүй гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тусгай ангийн зохих зүйл, хэсэгт зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Эрүүгийн хуульд зааснаар гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэнд “зэвсэг, хэрэгслийг хайж олсон, шинээр хийсэн, төхөөрч тохируулсан, хамтран оролцогчийг сонгож авсан, гэмт хэрэг үйлдэх талаар үгсэж тохиролцсон, түүнчлэн гэмт хэрэг үйлдэх бусад нөхцөл, боломжийг санаатай бүрдүүлснийг” үзнэ.

Гэмт хэрэг үйлдэхэд шууд чиглэсэн үйлдэл буюу эс үйлдэхгүйг санаатай хийсэн боловч тухайн этгээдийн хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас гэмт хэрэг туйлдаа хүрээгүй бол гэмт хэрэг үйлдэхээр завдсан гэж үзнэ. Хуулийн эдгээр заалтууд нь иргэдийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний алдар нэр хүндийг доромжлон харьцах гэмт хэргээс хамгаалах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чухал үүрэгтэй юм.

## **5 дугаар зүйл**

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 2 дугаар зүйлд “Монгол Улсын нутаг дэвсгэр дээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахад Үндсэн хуулийг удирдлага болгож, энэ хуулийг баримтална” гэж, 3 дугаар зүйлд “Монгол улсын нутаг дэвсгэрт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь гэмт хэрэг хаана гарсныг үл харгалзан

бүх нөхцөлд энэ хуулийн дагуу явагдана...” гэж, мөн “энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарах хилийн чанадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутаг, Монгол Улсын төрийн далбаа мандуулсан хөлөг онгоц, агаарын хөлөгт гарсан гэмт хэрэгт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахад нэгэн адил үйлчилнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Далай ашиглах тухай 1999 оны хуулийн 12 дугаар зүйлд тухайн хөлөг онгоц Монгол Улсад харьяалагдаж буйг тодорхойлох бэлгэ тэмдэг нь Монгол Улсын Төрийн далбаа байх бөгөөд Монгол улсын Төрийн далбаа мандуулах эрхийг Монгол улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоц эдэлнэ гэж заасан.

Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэн, харьяалалгүй хүний үйлдсэн гэмт хэрэгт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг явуулахдаа Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан журмыг баримтална. Дипломат дархан эрх, эрх ямба эдэлж байгаа гадаадын иргэн өөрөө хүссэн, эсхүл зөвшөөрсөн тохиолдолд мөн Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан журмыг баримтлан эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж болно.

Гадаад улсын дипломат дархан эрх, эрх ямба эдэлж байгаа этгээдэд холбогдуулан байцаан шийтгэх ажиллагаа явуулах зөвшөөрлийг Монгол Улсын гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар уламжлан хүснэ.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 14 дүгээр зүйлийн дагуу Монгол Улсын иргэн, тус улсад байнга оршин суудаг харьяалалгүй хүн гадаад улсад энэ хуульд заасан гэмт хэрэг үйлдэж, тухайн хэрэгтээ ял шийтгүүлээгүй бол энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэж заасан.

Эрүүгийн хуулийн 14 дүгээр зүйлд дараах зүйлийг тусгажээ:

- 1) Монгол Улсын иргэн, тус улсад байнга оршин суудаг харьяалалгүй хүн үйлдсэн гэмт хэрэгтээ гадаад улсад ял шийтгүүлсэн бол Монгол Улсын шүүх түүнд оногдуулсан ялыг энэ хуулийн дагуу хөнгөрүүлэх буюу ялаас чөлөөлж болно. Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол шүүх тухайн этгээдийг энэ хуульд заасан үндэслэлээр гэм буруугүйд тооцож болно. (14 дүгээр зүйлийн 2);
- 2) Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаад улсад алба хааж байхдаа гэмт хэрэг үйлдсэн Монгол Улсын цэргийн албан хаагчид энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ (14 дүгээр зүйлийн 3);
- 3) Монгол Улсын хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнд зөвхөн Монгол Улсын олон улсын гэрээнд заасан бол энэ хуулиар хариуцлага хүлээлгэнэ (14 дүгээр зүйлийн 4);
- 4) Монгол Улсад байнга оршин суудаггүй гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн тус улсын хилийн гадна Монгол улсын ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлээгүй бол Монгол улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэж болно (14 дүгээр зүйлийн 5) гэж тус тус заасан.

Түүнчлэн гадаад улсад гэмт хэрэг үйлдээд шалгагдаж байгаа, эсвэл Монгол Улсад гэмт хэрэг үйлдээд гадаад улсад баригдсан этгээдийг хэрхэн Монгол Улсад шилжүүлэн

авчирч эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 404 дүгээр зүйлд хуульчилжээ.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 405 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар гадаад улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн буюу шийтгэгдсэн гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнийг шилжүүлэн өгөх тухай гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтийг хууль, олон улсын гэрээ, хэлэлцээрт заасны дагуу шийдвэрлэнэ.

## **6 дугаар зүйл**

Гэмт этгээдийг шилжүүлэх, таслан сэргийлэх арга хэмжээ

1. Монгол Улсын иргэн гадаад улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэнийхээ дараа Монгол Улсад буцаж ирсэн бөгөөд гадаад улсын эрх бүхий байгууллага уг хэргийг шалгах хүсэлт ирүүлсэн бол байцаан шийтгэх ажиллагааг энэ хуульд заасан журмын дагуу явуулахаар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 403 дугаар зүйлд заасан. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 408 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтийг хангаж гэмт этгээдийг шилжүүлэн өгөх хууль зүйн үндэслэл байвал түүнийг баривчилж шилжүүлж өгөх хүртэл цагдан хорьж хүсэлт тавьсан байгууллагад шилжүүлэн өгөх цаг хугацаа, газрыг нэн даруй мэдэгдэнэ. Монгол Улсын Засгийн газраас гадаадын улс орнуудтай эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай байгуулсан гэрээнүүдэд дараах байдлаар тусгагдсан байна. Үүнд:

- БНСВУ-ын Засгийн газартай 2000 онд байгуулсан гэрээний 57-р зүйлд “шилжүүлэн өгөх тухай шаардлага хүлээн авмагц түүнийг хүлээн авсан хэлэлцэн тохирогч тал шилжүүлэн өгч болохгүй гэж энэ гэрээнд зааснаас бусад тохиолдолд шилжүүлэн өгвөл зохих этгээдийг цагдан хорих арга хэмжээг нэн даруй авна гэж заасан нь БНКуБ Улстай 1989 онд, БНКазахстан Улстай 1993 онд, БНУкраин Улстай 1995 онд байгуулсан эрх зүйн туслалцааны гэрээнүүдийн холбогдох зүйл заалтуудтай ижил байна.
- БНУнгар Ард Улстай 1968 онд байгуулсан гэрээний 56 дугаар зүйлд шилжүүлэн өгөх шаардлага хүлээн авсан хэлэлцэн тохирогч этгээд уг шаардлага хүлээн авмагц энэхүү гэрээний дагуу шилжүүлэн өгөхгүй байж болох тухай заалтад хамаарахгүй байвал шилжүүлэн өгөх этгээдийг нэн даруй баривчлах арга хэмжээ авна гэж заасан нь БНСЮгослав Улстай 1981, БНБолгар Ард Улстай 1968 онд, БНСолонгос Улстай 1999 онд БНСЧех Улстай 1976 онд, БНПУлстай 1998 онд байгуулсан эрх зүйн туслалцааны гэрээнүүдийн холбогдох зүйл заалттай адил байна.

2. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58 дугаар зүйлд зааснаар сэжигтэн оргон зугтахыг завдсан, эсхүл хүнд, онц хүнд гэмт хэрэгт сэрдэгдэх хангалттай баримт байгаа бол түүнийг баривчилна. Мөн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь сэжигтнийг баривчлах тухай тогтоол үйлдэж, прокурорт хүргүүлэх бөгөөд прокурор нь шүүхэд танилцуулж батлуулна.

Хойшлуулшгүй тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч сэжигтнийг шууд баривчилж, 24 цагийн дотор тогтоолыг прокурорт болон шүүхэд хүргүүлнэ. Шүүх



тогтоолыг хүлээн авснаас хойш 48 цагийн дотор баривчлагдаж байгаа этгээдийг цагдан хорих зөвшөөрөл өгөх буюу суллах үүрэгтэй. Баривчилснаас хойш 72 цаг дуусч тухайн этгээдийг цагдан хорих шүүгчийн шийдвэр ирээгүй бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчид мэдэгдэж, баривчлах байрны дарга түүнийг суллана. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 62 дугаар зүйлд зааснаар сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлж болох буюу эрүүгийн хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулж болох, эсхүл гэмт хэрэг үйлдэж болох үндэслэлтэй бол түүнд дараах таслан сэргийлэх арга хэмжээний аль нэгийг нь авч болно:

1. оршин суугаа газраасаа гадагш явж болохгүй тухай баталгаа авах;
2. батлан даалтад өгөх;
3. эд хөрөнгө барьцаалах;
4. цэргийн албан хаагчийг цэргийн ангийн удирдлагад хянан харгалзуулахаар өгөх;
5. цагдан хорих.

Таслан сэргийлэх арга хэмжээ авах талаар шүүх, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол, шүүгч захирамж гаргах бөгөөд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг зөвхөн шүүгч авна.

Эрүүгийн хуульд заасан хүнд, онц хүнд хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, түүнчлэн удаа дараа ял шийтгэгдэж байсан этгээд, онц аюултай гэмт хэрэгтэн дахин гэмт хэрэгт сэрдэгдсэн бол түүнийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлах, хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулах, гэмт хэрэг дахин үйлдэхээс сээрэмжлэх зорилгоор цагдан хорьж болно (Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйл).

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 69 дүгээр зүйлд зааснаар:

1. Сэжигтнийг цагдан хорьж мөрдөх хугацаа 14 хүртэл хоног байна.
2. Яллагдагчийг хорьж мөрдөх хугацаа 2 сар хүртэл байна.
3. Хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэргийн яллагдагчийг хэргийн төвөгтэй байдлыг харгалзан цаашид хорьж мөрдөх зайлшгүй шаардлагатай бол шүүх уг хугацааг сунгах боловч хорьж мөрдөх хугацаа хүндэвтэр гэмт хэрэгт 4 сараас, хүнд гэмт хэрэгт 12 сараас, онц хүнд гэмт хэрэгт 24 сараас хэтэрч болохгүй. Насанд хүрээгүй хүүхдийн хувьд цагдан хорих хугацааг хуульд богиносгон тогтоосон байдаг ба үндсэн хугацаа 1 сар байх ба сунгах шаардлагатай тохиолдолд хүндэвтэр гэмт хэрэгт 2 сараас, хүнд гэмт хэрэгт 4 сараас, онц хүнд гэмт хэрэгт 8 сараас хэтэрч болохгүй байхаар заасан.
4. Эрүүгийн хуулийн 81.2 /Төр, нийгмийн зүтгэлтний амь биед халдах/, 84 /Хорлон сүйтгэх/, 91.2 /Хүнийг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар санаатай алах/, 145.4 /Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хулгайлах/, 177.2 /Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар зандалчлах/, 302 /Төрлөөр устгах/ дугаар зүйлд заасан хэргийн яллагдагчийг энэ хуулийн 69.3–д зааснаас илүү хугацаагаар хорьж мөрдөх шаардлагатай бол шүүх 6 сар хүртэл хугацаагаар нэмж сунгаж болно.
5. Мөрдөн байцаагч хорьж мөрдөх хугацааг сунгах тухай үндэслэл бүхий тогтоол үйлдэж хугацаа дуусахаас 7 хоногийн өмнө прокурорт хүргүүлэх бөгөөд прокурор шүүхэд хүргүүлнэ.

6. Шүүгч цагдан хорих хугацааг сунгах тухай саналыг 72 цагийн дотор хянаж тогтоолыг батлах буюу татгалзана.
7. Нэг хэрэгт дахин, эсхүл тусгаарласан, нэгтгэсэн хэрэгт шинээр цагдан хоригдсон бол өмнө нь цагдан хоригдсон хугацааг нийт цагдан хоригдсон хугацаанд оруулж тооцно.
8. Шүүхээс нэмж мөрдөн байцаалгахаар буцаасан хэргийн яллагдагчийг цаашид хорьж мөрдөх хугацааг энэ хуулийн 69.2-т заасан хугацаанд оруулж тооцно.
9. Шүүхээс хэргийг хянан шийдвэрлэх шатанд яллагдагчийг хорьж мөрдөх хугацаа дуусвал тухайн шүүхийн Ерөнхий шүүгч хэргийг хянан шийдвэрлэхэд шаардагдах хугацаагаар захирамж гарган сунгаж болно гэж заасан.

3. “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай” хууль 1999 оны 7 дугаар сарын 1-ний өдөр батлагдсан бөгөөд энэхүү хуулийн зорилт нь эрх бүхий албан тушаалтнаас хуульд заасан үндэслэлээр гаргасан шийдвэрийн дагуу сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх нөхцөл, журмыг тодорхойлох, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Энэхүү хуулийн 3 дугаар зүйлд баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэхэд хууль дээдлэх, хүнлэг ёс, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх зарчмыг баримтална, албадан саатуулагдсан, цагдан хоригдсон этгээдэд эрүү шүүлт тулгах эсхүл бусад арга хэрэглэн түүний бие махбодыг тарчлаан зовоох буюу сэтгэл санааны дарамтад оруулахыг хориглоно гэж заасан. Мөн тус хуульд хорих байрны ажилтнуудад хоригдсон этгээдтэй хүнлэг бус харьцахыг хориглосон байна. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь сэжигтнийг баривчилсан болон хаана байгааг 24 цагийн дотор түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, төрөл, садангийн хүн эсхүл өмгөөлөгчид нь мэдэгдэх, эсхүл өөрөө мэдэгдэх боломжийг баривчлагдсан этгээдэд олгоно (Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 61 дүгээр зүйл). Мөн 24 цагийн дотор цагдан хорих шийдвэрийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч цагдан хоригдсон этгээдийн гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн, эсхүл өмгөөлөгчийн аль нэгэнд мэдэгдэнэ (68 дугаар зүйл) гэж заасан.

Хэрэв баривчлагдсан этгээд нь гадаад улсын иргэн бол 24 цагийн дотор гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар уламжлан тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газарт мэдэгдэх ба харьяалалгүй хүний хувьд энэ талаар ямар нэгэн зохицуулалт байхгүй болно.

Дээр дурдсанчлан 408 дугаар зүйлийн дагуу гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл гэмт этгээдийг баривчилж шилжүүлж өгөх хүртэл цагдан хорьж хүсэлт тавьсан байгууллагад шилжүүлэн өгөх цаг хугацаа, газрыг нэн даруй мэдэгдэнэ. Хэрэв цагдан хоригдсон этгээдийг 30 хоногийн дотор шилжүүлж аваагүй бол прокурорын тогтоолоор суллана. Ингэж сулласан этгээдийг шинээр хүсэлт тавьсан тохиолдолд дахин цагдан хорьж болно гэж заасан. Гадаадын иргэн Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэний дараа Монгол Улсаас гарч явсан бол уг хэргийг шалгах явцад цугларсан бүх материалыг хууль, олон улсын гэрээнд заасан журмын дагуу гадаад улсын холбогдох байгууллагад хүргүүлнэ (402 дугаар зүйл). Энэ хуулийн 403 дугаар зүйлийн 2-т заасны дагуу гадаад улсын нутаг

дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэний дараа Монгол Улсад буцаж ирсэн Монгол Улсын иргэний хэргийг гадаад улсын эрх бүхий байгууллага шалгасан материалыг хууль, олон улсын гэрээнд заасан журмын дагуу шилжүүлж авах ба энэ нь нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэнэ. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 409 дүгээр зүйлд зааснаар энэхүү хуульд заасан журмын дагуу гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнийг гадаад улсад шилжүүлэн өгөхдөө түүний гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан зэвсэг болон бусад зүйл, түүнчлэн гэмт хэргийн ул мөр бүхий, эсхүл гэмт үйлдлүүдийн замаар олж авсан эд зүйл, шаардлагатай бусад нотлох баримтыг шилжүүлнэ. Эдгээр нотлох баримтыг эрүүгийн өөр хэрэг шийдвэрлэхэд ашиглах шаардлагатай бол түүнийг шилжүүлэн өгөхөөс татгалзаж болно. Мөн гадаад улсын холбогдох байгууллага хэргийг шийдвэрлэж дуусмагц эдгээр эд зүйлийг буцааж өгөх тухай баталгаа гаргасан үед шилжүүлнэ гэж заасан болно.

### **7 дугаар зүйл**

Гэмт этгээдийг шилжүүлэн өгөхөөс татгалзах, хууль шүүхийн өмнө эрх тэгш байх Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 406 дугаар зүйлд зааснаар дараах тохиолдолд гэмт этгээдийг шилжүүлэн өгөхгүй:

1. Монгол Улсын иргэн;
2. гэмт этгээдэд Монгол Улсад орогнох эрх олгосон;
3. шилжүүлэн өгөх тухай шаардлагын үндэслэл нь Монгол Улсад гэмт хэрэгт тооцогддоггүй бол;
4. шилжүүлбэл зохих этгээд тухайн үйлдэлд урьд нь ял шийтгүүлж эдэлсэн, эсхүл уг хэргийг өмнө нь хэрэгсэхгүй болгосон бол;
5. Монгол Улсын хууль тогтоомжоор тухайн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан, эсхүл бусад үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэх буюу ял шийтгэж болохгүй нөхцөл байдал байгаа бол.

Эрүүгийн хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар Монгол Улсын хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнд зөвхөн Монгол Улсын олон улсын гэрээнд заасан бол энэ хуулиар хариуцлага хүлээлгэнэ. Монгол Улсад байнга оршин суудаггүй гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн тус улсын хилийн гадна Монгол Улсын ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлээгүй бол Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэж болно гэж заасан.

2. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт "... Монгол Улсын иргэн нь өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй ..." гэж зааснаас гадна Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 6 дугаар зүйлд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилт нь аливаа гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлж, гэмт этгээдийг олж тогтоох, гэмт хэрэг үйлдсэн этгээд нэг бүрт зохих ялыг шударгаар оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх явдлыг хангахад оршино" гэж, "Эрүүгийн

хуулийн 6 дугаар зүйлд ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдалд тохирсон байна” гэж тус тус заасан байна.

### **8 дугаар зүйл**

Гэмт этгээдийг шилжүүлэх гэрээ

Монгол улс нь эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай нийт 24 гэрээ байгуулснаас БНХАУ, БНСУ, БНЭУ–тай “Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай” гэрээ, БНСУ, БНКанадУ–тай “Ялтан шилжүүлэн өгөх тухай” гэрээ тус тус байгуулсан бөгөөд “Иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай” байгуулсан 12 гэрээнд гэмт этгээдийг шилжүүлэн өгөх талаар тусгасан байна.

Монгол Улсын байгуулсан гэмт этгээдийг шилжүүлэх асуудлыг зохицуулж буй хоёр талт энэхүү гэрээнүүдэд шилжүүлбэл зохих гэмт хэргийн жагсаалт байдаггүй бөгөөд гэмт этгээдийг нь шилжүүлж болох гэмт хэргийн хүрээг тухайн гэмт хэрэгт шүүхээр оногдуулж болох ялын хэмжээгээр тодорхойлдог. Ихэнхдээ эдгээр гэмт хэрэгт хэлэлцэн тохирогч талуудын хуулиар нэгээс доошгүй жилийн хорих ял оногдуулах гэмт хэргийг ойлгоно.

Конвенцийн дагуу эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж харьцах гэмт хэрэг эрх зүйн туслалцааны гэрээнүүдэд нарийн тусгагдаагүй ч түүнтэй дүйцэхүйц Эрүүгийн хуульд заасан гэмт хэргүүд нь шилжүүлэх гэмт хэргийн хүрээнд багтаж байгаа юм.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2008 оны 5 дугаар сарын 16–ны өдрийн нэгдсэн чуулганаар гишүүд санал нэгтгэйгээр “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Палермогийн конвенц болон түүний нэмэлт протоколуудад /Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол, Шилжин суурьшигчдыг газраар, далайгаар буюу агаараар хууль бусаар оруулахын эсрэг протокол, Галт зэвсэг, бүрдэл хэсэг, эд анги, галт хэрэгслийг хууль бусаар тээвэрлэх, үйлдвэрлэхийн эсрэг протоколд нэгдэн орсон тухай хуулийг соёрхон баталж нэгдэн орсон болно. Ингэснээр Монгол Улс нь энэхүү конвенцид хамаарах гэмт хэрэгт буюу зохион байгуулалттай гэмт хэргийн хувьд болон хүсэлт хүлээн авагч оролцогч улсын нутаг дэвсгэрт байгаа этгээдийг шилжүүлэх тухай хүсэлт, мөн хүсэлт гаргагч оролцогч улс болон хүсэлт хүлээн авагч оролцогч улсын дотоод хууль тогтоомжийн дагуу ял ногдуулах гэмт хэргийн хувьд энэхүү конвенцийг хамтран ажиллах эрх зүйн үндэс бүрдсэн. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 404 дүгээр зүйлд “Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэнйхээ дараа гадаад улсад гарсан Монгол Улсын иргэнийг шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг хууль, олон улсын гэрээ, хэлэлцээрт заасан журмын дагуу гадаад улсын эрх бүхий байгууллагад тавина” гэж, мөн хуулийн 405 дугаар зүйлд “гадаад улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн буюу шийтгэгдсэн гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнийг шилжүүлэн өгөх тухай гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтийг хууль, олон улсын гэрээ, хэлэлцээрт заасны дагуу шийдвэрлэнэ” гэж, 410 дугаар зүйлд “Монгол Улсын шүүхээр хорих ял шийтгүүлсэн этгээдийг харьяат улсад нь шилжүүлэн өгөх түүнчлэн гадаад улсын шүүхээр хорих ял шийтгүүлсэн Монгол Улсын

иргэнийг Монгол Улсад шилжүүлэн авах асуудлыг тухайн улстай байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээнд заасан нөхцөл журмын дагуу гүйцэтгэнэ” гэж тус тус заасан болно. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 46 дугаар бүлэгт гэмт этгээдийг шилжүүлэн өгөх, 47 дугаар бүлэгт ялтан шилжүүлэн өгөх талаар тус тус ерөнхийд нь зохицуулж өгсөн байна.

## **9 дүгээр зүйл**

### **Даалгавар гүйцэтгэх**

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 398 дүгээр зүйлд:

1) Гадаад улсын нутаг дэвсгэрт байцаалт, үзлэг, нэгжлэг, туршилт, эд хөрөнгө хураан авах болон энэ хуульд заасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн бусад ажиллагаа явуулах шаардлагатай бол уг асуудлыг эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай болон олон улсын бусад гэрээ, хэлэлцээрийн дагуу гүйцэтгэнэ.

2) Байцаан шийтгэх тодорхой ажиллагаа явуулах даалгаврыг олон улсын гэрээ, хэлэлцээрт заасан байгууллагаар дамжуулан явуулна гэж заасан. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 399 дүгээр зүйлд зааснаар байцаан шийтгэх тодорхой ажиллагааг явуулах тухай даалгаврыг бичгээр үйлдэх ба түүнд дараах зүйлийг заана:

1. даалгавар өгч байгаа байгууллагын нэр;
2. даалгавар хүлээн авах байгууллагын нэр;
3. даалгаврын утга ба хэргийн агуулга;
4. даалгавартай холбоотой этгээдийн иргэний харьяалал, эрхэлдэг ажил, оршин суугаа буюу байрлаж байгаа газрын талаарх мэдээлэл, хуулийн этгээдийн хувьд түүний нэр, хаяг;
5. эд мөрийн ба бусад баримт;
6. зүйлчлэлийн тухай мэдээлэл, шаардлагатай бол учирсан хохирлын хэмжээ.

Даалгавар түүнд хавсаргаж байгаа баримт бичиг, нотлох баримтыг хүлээн авагч улсын албан ёсны хэл дээр орчуулж, эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, шаардлагатай бол тэмдэг дарна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 400 дугаар зүйлд зааснаар олон улсын гэрээ, хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол гадаад улсад байнга буюу түр хугацаагаар оршин сууж байгаа Монгол Улсын харьяат гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч, шинжээчийг тухайн улс дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан дуудаж болох бөгөөд гадаад улсын харьяат гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний өмгөөлөгч, төлөөлөгч, шинжээчийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон тухайн улсын эрх бүхий байгууллагаар дамжуулан дуудна. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 401 дүгээр зүйлд зааснаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн байгууллага нь байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай гадаад улсын холбогдох байгууллага, албан тушаалтны даалгаврыг хуульд заасан нийтлэг журмын дагуу биелүүлнэ. Даалгаврыг биелүүлэхэд тухайн улстай байгуулсан олон улсын гэрээнд заасан бол гадаад улсын байцаан шийтгэх ажиллагааны хэм хэмжээг хэрэглэж болох бөгөөд

даалгаврыг биелүүлэхэд гадаад улсын холбогдох байгууллагын төлөөлөгч байлцаж болно. Даалгаврыг биелүүлэх боломжгүй тохиолдолд олон улсын гэрээ, хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Улсын ерөнхий прокурорын газар, эсхүл хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан даалгавар өгсөн гадаадын байгууллагад биелүүлээгүй шалтгааныг зааж, хүлээн авсан баримт бичгийг буцаана.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 402, 403 дугаар зүйлд зааснаар гадаадын иргэн Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэнийхээ дараа Монгол Улсаас гарч явсан бол уг хэргийг шалгах явцад цугларсан бүх материалыг хууль, олон улсын гэрээнд заасан журмын дагуу гадаад улсын эрх бүхий байгууллагад хүргүүлэх бөгөөд гадаад улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэнийхээ дараа Монгол Улсад буцаж ирсэн Монгол Улсын иргэний хэргийг гадаад улсын эрх бүхий байгууллага шалгасан материалыг хууль, олон улсын гэрээнд заасан журмын дагуу шилжүүлж авах ба энэ нь нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэнэ.

## **10 дугаар зүйл**

### **Сургалт, ёс зүй**

Монгол Улс нь баривчлах, саатуулах, байцаах эрхтэй болон цагдан хорих, хорих газарт ажилладаг хуулийн байгууллагуудын ажилтан албан хаагчдын дунд хүний эрхийн чиглэлээр болон эрүүдэн шүүх, хүнлэг бус харьцах асуудлаар сургалтын хөтөлбөр баталж хэрэгжүүлэхэд онцгой анхаарч байна.

1. Ялангуяа ХЭҮК байгуулагдсанаас хойш энэ төрлийн сургалтыг төрөл бүрийн хэлбэрээр тогтмол явуулж байна. Монгол Улсад хүний эрхийг хамгаалсан бие даасан байгууллага бий болсон нь хүний эрхийг хамгаалах, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг томоохон баталгаа, хамгаалалт бий болсон.

Өнгөрсөн хугацаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдын хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр НҮБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Эмнести интернэшнл, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв зэрэг байгууллагууд хамтран ажиллаж хүний эрхийг хамгаалах талаар төрөл бүрийн сургалтуудыг зохион байгуулсан.

Мөн тус улсад хэрэгжиж байгаа гадаад орнуудын янз бүрийн төслийн хүрээнд хүний эрхийн болон эрүүдэн шүүхийн эсрэг сэдвээр шат дараалсан сургалт явагдаж, мэдээллээр хангах ажил тогтмол хийгдэж ирлээ.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих ангиудын “Ахуй дэглэмийн байцаагч” нарын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн “Нийгмийн ажилтан” болгож, тэдгээрийг 2003 онд Шинжлэх ухаан техникийн их сургуулийн Хүмүүнлэгийн ухааны сургуулийн нийгмийн ажилтан бэлтгэх сургалтад хамруулан мэргэжлийн багш нараар хичээл заалган дадлагажуулсны зэрэгцээгээр 2004 оныг “Нийгмийн ажилтны үйл ажиллагааг хэвшүүлэх жил” болгох зорилт дэвшүүлэн ажилласан. Уг зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа төвлөрсөн хорих ангиудын дунд “Нийгмийн ажилтны үйл ажиллагааг хэвшүүлэх” уралдааны болзол зарлан ажиллуулсан бөгөөд уралдааны

гол зорилго нь хорих ангид ял эдэлж буй ялтнуудын дунд зохиох сургалт, хүмүүжлийн ажил, тэднийг нийгэмшүүлэх, амьдралын эрүүл дадал, арга барил эзэмшүүлэх, ялтны дунд шинээр гэмт хэрэг үйлдэх, хорих ангиас оргох, ял эдлэхээс зайлсхийх болон хорих ангийн дотоод дэг журам зөрчихөөс урьдчилан сэргийлэх, хорих ангийн ажилтнууд тэдэнтэй хууль журмын дагуу зөв боловсон харьцах, хуулиар тогтоосон эрх, эрх чөлөөг нь зөрчихгүй байлгах талаар дотооддоо сургалт явуулах, хяналтыг сайжруулах, үр нөлөөг нь дээшлүүлэхэд чиглэгдсэн. Түүнчлэн 2008–2009 онд хэрэгжүүлэх нийгмийн ажлын хөтөлбөрийг боловсруулан гаргаад байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар хорих ангиудад нийт 70 гаруй нийгмийн ажилтан ажиллаж байна. Гэмт хэрэг үйлдэн ял шийтгэгдсэн насанд хүрээгүй хүүхдүүдийн засрал хүмүүжлийг сайжруулах, тэдний нийгмийн амьдралд бие даан орох сэтгэл зүйн бэлтгэлийг хангах, нийгэмшүүлэх, мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд анхаарч 2001 онд Хүүхдийн хорих ангийн дэргэд Ерөнхий боловсролын тусгай сургууль байгуулан сургалт хичээл явуулахын зэрэгцээ дархан, мужаан, гар урлал, оёдлын мэргэжил эзэмшүүлэх сургалт явуулж анхан шатны мэдлэг, дадлага эзэмшүүлж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хэмжээнд жил бүр уламжлал болгон “Албан хаагчдын өвөл цагийн сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулан баталж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, хорих ангийн албан хаагчдын дунд сургалт зохион явуулж ирсэн. 2000 оноос хойш энэхүү сургалтад давхардсан тоогоор нийт 9100 гаруй албан хаагч хамрагдсан байна.

Энэхүү хөтөлбөрт НҮБ-аас олон улсын эрх зүйн хүрээнд хүний эрхийн талаар гаргасан баримт бичиг, олон улсын гэрээ конвенциудыг өргөн хүрээтэй тусгадаг ба Хууль зүйн үндэсний хүрээлэн, их, дээд сургуулийн багш нар, холбогдох мэргэжлийн байгууллагуудад түшиглэн сургалтуудаа явуулж байна.

3. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцахыг хориглосон асуудлаар тодорхой сэдвийг Цагдаагийн академийн сургалтын хөтөлбөрт тусган сонсогч, оюутнуудад хичээл зааж байна.

Мөн дээрх сэдвээр алба хаагчдад зориулсан богино хугацааны сургалтыг албадуудын хэмжээнд зохион байгуулагддаг бөгөөд жил бүр тусгай хөтөлбөрөөр явуулдаг албаны хичээлийн хөтөлбөрүүдэд мөн тусган заадаг. Монгол Улсын ХЭҮК-той хамтран 2004, 2005 онд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бус харьцаж хүнийг гомдоох, нэр төрийг нь гутаахгүй байхад цагдаагийн алба хаагчдын анхаарах асуудлаар тусгай хөтөлбөрийн дагуу нийслэлийн 6 дүүргийн бүх офицеруудад дүүрэг бүрээр нь нэг нэг өдрийн сургалтыг зохион байгуулж 500 гаруй алба хаагчдыг хамруулав. Сүүлийн 3 жилд Монголын ХЭҮК, Эрх зүйн боловсролын академи /Хайнс Зайделын сан/, Хууль зүйн үндэсний хүрээлэн зэрэг байгууллагуудаас зохион байгуулсан хүний эрх, эрх чөлөөг хангах, Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн шинэчлэл, цагдаагийн алба хаагчдын зан үйл зэрэг сэдэвт сургалтуудад төв, орон нутгийн цагдаагийн байгууллагын 800 гаруй алба хаагчдыг хамруулан суралцуулсан байна.

Цагдаагийн албан хаагчдад зориулан явуулж байгаа төрөл бүрийн сургалтын агуулгад НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1979 оны тогтоолоор батлагдсан “Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль”-ийн үзэл санааг байнга

тусган зохион байгуулж байна.

4. Цагдаагийн алба хаагчдаас иргэдтэй харьцахад баримтлах зан үйл, ёс зүйн хэм хэмжээ, зарчмуудыг “Цагдаагийн алба хаагчдын ёс зүйн дүрэм”, “Мөрдөн байцаагчдын ёс зүйн дүрэм”, “Хэрэг бүртгэгчдийн ёс зүйн дүрэм”, “Цагдаагийн академийн дотоод журам”, “Цагдаагийн алба хаагчдын ажил үйлчилгээний стандарт” зэрэг баримт бичгүүдэд тусган хэрэгжүүлж байна.

Мөрдөн байцаагчийн ёс зүйн дүрмийн 7 дугаар зүйлд “Мөрдөн байцаагч бүр эрүүгийн гэмт хэрэгт холбогдуулан мөрдөн шалгаж байгаа хүнийхээ хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалан хүндэлнэ”, 15 дугаар зүйлд “Мөрдөн байцаагч нь хуульд заасан журмаас гадуур мөрдөн байцаалтын арга хэрэглэх, хуулийг зориуд буруу хэрэглэх, сэжигтэн яллагдагчийн хууль ёсны ашиг сонирхолд харш үйл ажиллагаа явуулах эрхгүй” гэж зааснаас гадна Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм, Хэрэг бүртгэгчийн ёс зүйн дүрэмд мөн энэ талаар болон хүний эрх, эрх чөлөөг хамгаалж хүндэтгэн, хуулийг дээдэлж, шудрагаар ажиллах тухай тус тус тусгаж өгсөн.

Түүнчлэн Улсын ерөнхий прокурорын дэргэдэх мөрдөн байцаах алба нь тусдаа албаны болон мөрдөн байцаагчийн ёс зүйн дүрмийг мөрдөн ажиллаж байна. Тухайлбал: Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албаны “Мөрдөн байцаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.3-т “Мөрдөн байцаагч нь албан үүргээ хэрэгжүүлэхдээ бусдад эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандах, бусдын нэр төрийг доромжлох, айлган сүрдүүлэх, үзэл бодлоо тулган хүлээлгэж болохгүй” гэж заасан.

Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу “Хорих ангийн дотоод журам”, “Хорих ангийн харуул хамгаалалтын болон ялтанд хяналт тавих журам”, “Сахилгын байр, тусгаарлах тасалгааны нөхцөл, журам”, “ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх журам” зэргийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар батлан мөрдөж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйн болон сахилгын дүрэмд энэхүү конвенцийг хэрэгжүүлэх үүднээс хэд хэдэн заалт тусгаж өгсөн байна.

Улсын Их хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрт “Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр доромжлон хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг гутаан харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн заалтыг практикт нэвтрүүлж хэвшүүлэх, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарт заавар, зөвлөмж өгч, сургалт явуулж, тэдний хариуцлагыг тодорхой болгоно” гэж заасны дагуу уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2007, 2008 оны төлөвлөгөөнд энэ чиглэлээр тодорхой арга хэмжээ тусган хэрэгжүүлж байна.

## 11 дүгээр зүйл

Баривчлах, цагдан хорих ажиллагаа, өмгөөлөл

1. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт “Монгол Улсын иргэн халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь



доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэсэн нь баривчлагдсан, албадан саатуулагдсан хүмүүсийн эрхийг хамгаалах, хууль ёсны дагуу байлгах үндэслэл юм.

Урьд нь гэмт хэрэгт сэжиглэгдсэн хүмүүсийг түр саатуулах, албадан саатуулах, цагдан хорих саналыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч гаргаж прокурор баталдаг байсан бол 2002 оноос сэжигтнийг баривчлах, цагдан хорих зөвшөөрлийг шүүгч олгодог болсон.

Цагдан хорих зөвшөөрлийг шүүгч өгдөг болж хорьж мөрдөх үндэслэл, журмыг шинэчилж баталснаар үндэсний хууль тогтоомжийг олон улсын гэрээ, конвенц, дэлхий нийтийн жишигт нийцүүлж, цагдан хоригдогсдын тоо буурч /нийтлэг хэрэглэх нь багасч/ зарим нааштай ахиц, өөрчлөлт ажиглагдаж байна.

Хэдийгээр шүүх цагдан хорих зөвшөөрлийг олгож байгаа боловч хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58, 59 дугаар зүйлд заасан хойшлуулшгүй тохиолдолд ийм шийдвэр гаргаж улмаар прокурор шүүхэд мэдэгдэх эрхтэй. Энэхүү хойшлуулшгүй ажиллагааны явцад хүний эрх зөрчигдөхөөс сэргийлэхийн тулд нийслэлийн Цагдан хорих 461-р ангид 4 прокурор байнга ажиллуулж тэдгээрийн үйл ажиллагааг Монгол Улсын Ерөнхий прокурор 2007 оны 9 дүгээр сард гаргасан 274 дүгээр тушаалаар зохицуулж байгаа нь үр дүнгээ өгч байна.

2. Монгол Улс хорьж мөрдөх хугацааг үе шаттайгаар бууруулах бодлогыг тууштай баримталж байна. Тухайлбал 1994 он хүртэл хорьж мөрдөх хугацааны дээд хязгаар байгаагүй бол 1994 оны хуулиар цагдан хоригдох хугацаа 2 сараас хэтрэхгүй байхаар, онц хүнд гэмт хэргийн яллагдагчийг хэргийн байдлыг харгалзан шаардлагатай гэж үзвэл 36 сар хүртэл хугацаагаар цагдан хорьж болохоор, харин 2002 оны хуулиар хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэргийн яллагдагчийг хорьж мөрдөх хугацааг 24 сараас хэтэрч болохгүй байхаар, зарим төрлийн онц хүнд гэмт хэргийн /69 дүгээр зүйл/ яллагдагчийн хувьд 30 сар хүртэл хугацаагаар сунгаж болохоор тус тус заасан. 2007 оны 8 дугаар сараас хүндэвтэр гэмт хэрэгт 4 сараас, хүнд хэрэгт 12 сараас, онц хүнд гэмт хэрэгт 24 сараас хэтрэхгүй хугацаагаар яллагдагчийг хорьж мөрдөхөөр тус тус зааж, бусдыг удаан хугацаагаар хорьдог явдлыг багасгаж байна.

3. Үндсэн хуульд хүнийг баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ гэж заасан. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд дээрх хугацааг тодорхой зааж 24 цагаар тогтоосон бөгөөд тус улсын иргэний тухайд гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, төрөл садангийн хүн, өмгөөлөгчид нь мэдэгдэх эсхүл өөрөө мэдэгдэх боломжийг баривчлагдсан этгээдэд олгохоор заасан бол гадаад улсын иргэний тухайд мөн хугацаанд Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар уламжлан тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газарт мэдэгдэж байхаар хуульчилсан. Хуульд өмгөөлөгчийг заавал оролцуулах нөхцлүүдийг тусгаж өгсөн бөгөөд хуулийн энэ зохицуулалт бүрэн хэмжээнд хэрэгжиж байна.

4. Монгол Улсад шүүн таслах ажиллагаа мэтгэлцэх зарчмын дагуу явагдах талаар 1994 онд анх удаа Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хуульчилсан бөгөөд 2002 онд

батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар үүнийг агуулгын хувьд улам тодотгосон.

Нөгөөтэйгүүр мэтгэлцэх зарчмыг шүүн таслах ажиллагаанд тууштай явуулахын тулд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд мэтгэлцэх нэг тал болох өмгөөлөгчийн эрх, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь түүний оролцоог өргөтгөсний зэрэгцээ өмгөөлөх ажиллагааг аль болох эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны эхний үе шатнаас явуулахаар хуульчлан заасан. Тухайлбал: 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар гэмт хэрэгт сэжигтнээр тооцогдсон үеэс, 2007 оны 8 дугаар сард тус хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр “хойшлуулшгүй ажиллагаа явуулж эхэлсэн” үеэс хүн өөрийгөө өмгөөлүүлэх, өмгөөлөгчөөр хангагдах боломжтой болсон нь мөн л хүний эрх, эрх чөлөөг тууштай хангах, эрүүдэн шүүхтэй тэмцэх ажлын хүрээнд хийгдсэн чухал зохицуулалт болсон юм.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 41.3–д заасны дагуу өмгөөлөгч нь хэрэгт оролцох үеэс сэжигтэн, яллагдагчтай ганцаарчлан уулзах, тэдгээрийг байцаахад байлцах, асуулт тавих, хууль зүйн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад нотлох баримт цуглуулах талаар хүсэлт тавих, гаргаж өгөх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дууссаны дараа хэргийн бүх материалтай танилцах, төр, байгууллага, хувь хүний нууцад үл хамаарах нотлох баримтыг өөрийн зардлаар хувилах, хуулбарлан авах, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын шийдвэрт гомдол гаргах зэрэг эрх эдлэх болсон. Энэ нь өмгөөлөгчийн зүгээс цаашид шүүх хуралдааны явцад мэтгэлцэх ажиллагаанд идэвхтэй оролцох боломжийг бүрдүүлж өгч буй явдал юм.

Ийм заалтуудад Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дараах зүйл хэсгүүдийг дурьдаж болох юм. Үүнд: сэжигтнийг баривчлах үед түүнд баривчилсан шалтгаан үндэслэлийг мэдэгдэж, өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг заавал сануулна /10 дугаар зүйл/, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь сэжигтэн, яллагдагчийг өмгөөлүүлэх бололцоогоор заавал хангах /18.2/, баривчлах тухай тогтоолыг сэжигтэнд танилцуулж, улмаар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх, түүний дотор өмгөөлөгчийн хамт мэдүүлэг өгөх эрхтэй болохыг тайлбарлах /59.3/, тэрчлэн ямар хэрэгт сэрдэгдэж байгааг сэжигтэнд тэр даруй, харин түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, эсхүл өмгөөлөгчид нь 48 цагийн дотор мэдэгдэх /35.4/, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 40 дүгээр зүйлд заасан тохиолдолд сэжигтэн, яллагдагчид холбогдох хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад өмгөөлөгчийг заавал оролцуулах /40.1/ зэрэг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид үүрэг болгосон хэм хэмжээ, мөн сэжигтэн, яллагдагчийн хувьд өмгөөлөгчөө өөрөө сонгох ба мөн тэдний зөвшөөрснөөр буюу хүссэнээр хууль ёсны төлөөлөгч, гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүн нь өмгөөлөгчийг сонгон авах, ямар хэрэгт сэрдэгдэж буюу яллагдагч байгааг мэдэх, өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгч авах, өмгөөлөгчтэйгөө ганцаарчлан уулзах зэрэг эрхүүд /35, 36 дугаар зүйл/ багтана.

5. Үндсэн хуулийн 56.1 зүйлд “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэж заасан ба прокурорын байгууллага ял эдлүүлэх дараах ажиллагаанд хяналт тавьж байна.

Үүнд:

1. баривчлах, хорих болон бусад төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хуульд заасан үндэслэл журмын дагуу явагдаж байгаа эсэх;
2. баривчлах болон хорих ял эдлүүлэх ажиллагаа хуулиар тогтоосон нөхцөл, дэглэмд нийцэж байгаа эсэх;
3. эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэглэж байгаа эсэх;
4. ял эдэлж байгаа этгээдийн хууль ёсны эрхийг хангаж байгаа эсэх;

Прокурор дээрх хяналтыг тавихдаа дараах бүрэн эрхийг хэрэгжүүлж байна.

1. шийтгэх тогтоолыг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан хугацаанд ирүүлэхийг шүүхээс шаардах,
2. баривчлах, хорих ял эдлүүлэх газарт ямар ч цагт саадгүй нэвтрэх, ял эдлүүлэх үндэслэл болсон тогтоол, шийдвэр, баримт бичигтэй танилцах, ялтантай биечлэн уулзах, шаардлагатай бол тайлбар гаргуулах, тодорхойлолт авах;
3. ял эдлэлтийн байдлыг шалгах, танилцах, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;
4. шүүхийн шийдвэр гүйцэтгэх талаар хуульд тусгайлан заасан тохиолдолд дүгнэлт гаргах, шинжээч томилох;
5. баривчлах, хорих ял эдлүүлж байгаа нөхцөл, дэглэмийг шалгах, хууль бусаар хоригдож байгаа хүнийг нэн даруй суллах;
6. тогтоол биелүүлэхийг хойшлуулах, торгох, албадан ажил хийлгэх ялыг өөр ялаар солих, өвчний учир ял эдлүүлэхээр чөлөөлөх, хугацаанаас өмнө ялаас чөлөөлөх, эдлээгүй үлдсэн ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих, гянданд эдлүүлэх ялыг хорих ангид эдлүүлэхээр солих, хорих ангид эдлэх ялыг гянданд хорихоор солих асуудлыг шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцож дүгнэлт гаргах зэрэг болно.

Түүнчлэн УИХ-аас 1999 онд баталсан “Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай” хуулийн хэрэгжилтэд прокурор доорхи байдлаар хяналт тавьж /45 дугаар зүйл/ байна. Үүнд:

1. Хорих байрны үйл ажиллагаа, нөхцөл, журам нь энэ хуульд хэрхэн нийцэж байгаад хяналт тавих;
2. хорих байранд ямар ч цагт саадгүй нэвтрэх;
3. хоригдсон этгээд, бусад хүмүүстэй уулзах;
4. хоригдсон этгээдийн хувийн хэрэг болон шаардлагатай бусад материалтай танилцах;
5. өргөдөл, санал, гомдол, хэрэг зөрчлийг хянах, шалган шийдвэрлэх.

Энэ хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад хуульд заасан үндэслэл, журмын дагуу гаргасан прокурорын шийдвэрийг хорих байрны захиргаа, ажилтан биелүүлэх үүрэгтэй байхаар заасан.

Үүний дагуу зөвхөн прокурорын байгууллага хорих, баривчлах, цагдан хорих байрны ахуй нөхцөл, ял эдэлж байгаа ялтны хууль ёсны эрхийг хамгаалан байнгын хяналт тавин

**ДОЛООДУГААР БҮЛЭГ**

ажиллаж байна.

Прокурорын байгууллагаас цагдан хорих, ял эдлүүлэх ажиллагаанд 2000–2007 онд хийсэн хяналт шалгалтын ажлын зарим тоон үзүүлэлтийг дор дурдсан хүснэгтээр харуулав. Үүнд:

*Нэг. Хяналт шалгалтын ажлын үзүүлэлт:*

№	Ажлын үзүүлэлт	2000 он	2001 он	2002 он	2003 он	2004 он	2005 он	2006 он	2007 он	Бүгд
1	Хийсэн шалгалт	388	396	304	346	561	428	542	530	3495
2	Хяналт, шалгалтаар									
	Илрүүлсэн зөрчил	1376	1569	6883	2969	3740	2825	1969	2764	24095
	Арилгуулсан зөрчил	873	1158	6036	2619	3333	1982	1899	2238	20138
3	Бичсэн мэдэгдэл, шаардлага	252	308	364	266	375	365	276	379	2585
4	Арга хэмжээ авахуулсан албан тушаалтны тоо	188	198	256	210	227	175	149	229	1632
5	Зөрчигдсөн эрхийг сэргээсэн хүний тоо	1676	2193	1410	594	893	603	295	497	8161

*Хоёр. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт заасан заалтын дагуу прокурор хоригдогчийг сулласан байдлын судалгаа.*

Он	Хууль бусаар баривчлагдсан		Цагдан хоригдсон		Илүү хугацаагаар хоригдсон		Нийт сулласан хүн
	Хүний тоо	Үүнээс сулласан хүн	Хүний тоо	Үүнээс сулласан хүн	Хүний тоо	Үүнээс сулласан хүн	
2002 оны 9 сараас хойш	15	15	15	15	3	3	33
2003	25	25	4	4	8	8	37
2004	33	33	2	2	4	4	39
2005	39	39	2	2	4	4	39
2006	48	48	–	–	16	16	64
2007	46	46	4	4	1	1	51
Дүн	206	206	28	28	46	46	280

6. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 105 дугаар зүйлд заасны дагуу хорих байгууллага нь баривчлах байр, насанд хүрээгүйчүүдийн болон

насанд хүрэгсдийн хорих анги, гяндан тэдгээртэй адил дэглэм бүхий байгууллагаас бүрдэнэ.

Мөн хуулийн 106 дугаар зүйлд хорих ангийг шинээр байгуулах, өөрчлөх, татан буулгах, байршлыг өөрчлөх асуудлыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэхээр заасан.

2009 оны 3 дугаар сарын байдлаар Монгол Улсад 21 төвлөрсөн хорих анги, 25 баривчлах, цагдан хорих байр хуулиар тогтоосон үндэслэл, журмын дагуу байгуулагдан прокурорын хяналтын доор ажиллаж байгаа бөгөөд эдгээр баривчлах, хорих ангиуд нь бүгд нийтэд ил тод, албан ёсоор танигдсан газрууд юм. Өөрөөр хэлбэл Монгол Улсад нууцаар хүнийг хорих газар байхгүй бөгөөд энэ талаарх гомдол, мэдээлэл хууль хяналтын байгууллага болон хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зорилго, чиглэл бүхий төрийн болон төрийн бус байгууллагуудад ирж байгаагүй байна.

Харин 2006 онд Дорноговь аймгийн Их хэт, Айраг сумдын Засаг даргын тамгын газрын дэргэд байгуулсан түр саатуулах байр, Өмнөговь аймгийн Гурван тэс сумын цагдаагийн тасгийн эрүүлжүүлэх, албадан саатуулах байрууд стандартын шаардлага хангаагүй, прокурорын зөвшөөрөлгүй ажиллуулж байсныг хаасан.

Мөн Дорнод аймгийн Чойбалсан, Халх гол, Баян-Уул сумдад ажиллаж байсан эрүүлжүүлэх, түр саатуулах байруудын үйл ажиллагаа хууль зөрчсөн тул бүрэн зогсоожээ. Энэ мэтчилэн шаардлага хангаагүй, зохих зөвшөөрөлгүй ажиллаж байсан эрүүлжүүлэх, түр саатуулах 8 байрны үйл ажиллагааг зогсоосон.

Монгол Улсын Ерөнхий прокурор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2006 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 347/А173 тоот хамтарсан тушаалаар “Цагдан хорих байранд хоригдсон этгээдийн өрөөг солих, бусад өрөөнд шилжүүлэх” асуудлыг журамлаж, бүх хорих ангиудад телекамерын хяналтын систем тогтоосон нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хоригдогсдын өрөөг дур мэдэн сольж хэрэг хүлээлгэх зорилгоор дарамтлах, айлган сүрдүүлэх явдал гаргахаас урьдчилан сэргийлэх чухал ажил болсон.

## **12 дугаар зүйл**

Эрүүдэн шүүхтэй холбоотой хэргийг шалгах

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар эрүүдэн шүүхтэй холбоотой гэмт хэрэгт мөрдөн байцаалтыг дараах байгууллага явуулна:

- а) Улсын ерөнхий прокурорын дэргэдэх мөрдөн байцаах алба нь цагдаагийн байгууллагын ажилтан, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн болон тагнуулын байгууллагын ажилтны үйлдсэн /ЭБШ хуулийн 27.1-д зааснаас бусад/ хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулах;
- б) Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагч нь Эрүүгийн хуулийн 263.2./Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах/, 264.2./Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх/, 265/Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах/, 266.2./Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ

хэтрүүлэх/, 268/Хээл хахууль авах/, 269/Хээл хахууль өгөх/, 270.2./Хээл хахууль зуучлах/, 273.2./Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/ дугаар зүйлд заасан гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулах;

- в) Цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагч нь дээр дурьдсанаас бусад хүндэвтэр, хүнд, онц хүнд хэрэгт болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 27–р зүйлийн 1–т заасан гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулахаар тус тус заасан.

2. Прокурор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хуулийн заалт хэрхэн хэрэгжиж байгаад хяналт тавьж, шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцоно. Прокурор байцаан шийтгэх ажиллагаанд оролцоходоо Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 193, 195 дугаар зүйлд заасан болон хуулиар олгосон бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

3. Цагдаагийн албан хаагч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, хуулийн байгууллагын ажилтнуудын үйлдсэн хэргийг мөрдөн байцаах эрх бүхий албыг прокурорын байгууллагын дэргэд байгуулснаар улсын байгууллага өөрийн ажилтнуудын үйлдсэн эрүүдэн шүүхтэй холбоотой гэмт хэргийг мөрдөн шалгадаг тогтолцоог халсан юм.

Шүүхийн албан ёсны статистик мэдээнээс үзвэл эрүүдэн шүүх хэлбэрээр мэдүүлэг авч ял шийтгэл хүлээсэн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, хуулийн ажилтнууд сүүлийн гурван жилийн судалгаа гараагүй байна. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон шүүх прокурорын байгууллагын ажилтнуудаас хэргийн холбогдогч, сэжигтэн, яллагдагч нартай хүнлэг бус, харгис, хэрцгий хандсан хэргээр /Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйл/ 2002 оноос хойши хугацаанд 1 хүн шүүхээр шийтгэгдсэн байна.

### **13 дугаар зүйл**

Өргөдөл гомдол гаргах, шийдвэрлэх

Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын иргэн:

- Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд гомдол гаргах эрхтэй,
- төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй.

Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй гэж заасан.

Мөн Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 1–т шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана гэж хуульчилсан нь энэхүү конвенцийн 13 дугаар заалт хэрэгжих үндэс болж байна.

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 170 дугаар зүйлийн дагуу гэмт хэрэг үйлдсэн буюу үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай гомдол, мэдээллийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албаны дарга, эсхүл хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор нь заавал хүлээн авах үүрэгтэй. Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг 5 хоногт багтаан хянаж эрүүгийн хэрэг үүсгэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ. Нэмэлт тайлбар, баримт бичиг, бусад материал гаргуулж авах, хэргийн газарт үзлэг хийх шаардлагатай бол энэхүү хугацааг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албаны дарга 14 хүртэл хоногоор сунгаж болно.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 102 дугаар зүйлийн дагуу байцаан шийтгэх

ажиллагаанд оролцогч нь тодорхой байцаан шийтгэх ажиллагаа явуулах, хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг шалган тогтоох, түүнчлэн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах тухай хүсэлтийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх болон шүүгчид гаргах эрхтэй. Хүсэлтийг байцаан шийтгэх ажиллагааны аль ч үе шатанд гаргаж болох бөгөөд хүсэлтийг хангаагүй явдал нь байцаан шийтгэх ажиллагааны тухайн болон өөр үе шатанд түүнийг дахин гаргах эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй. Энэхүү хүсэлтийг боломжтой бол шууд, боломжгүй бол түүнийг гаргаснаас нь хойш 5 хоногийн дотор хангах эсэхийг шийдвэрлэнэ. Хүсэлт нь хэргийг тал бүрээс нь бүрэн, бодитойгоор тогтоох, оролцогч болон бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад ач холбогдолтой бол түүнийг хангах ба бусад тохиолдолд хэрэгсэхгүй болгоно. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх хүсэлтийг бүрэн болон хэсэгчлэн хангах, эсхүл хангахаас татгалзах тухай үндэслэл бүхий тогтоол, захирамжийг гаргах ба түүнд энэ хуульд заасан журмын дагуу гомдол гаргаж болно. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 106 дугаар зүйлд зааснаар байцаан шийтгэх ажиллагааны оролцогч, түүнчлэн уг ажиллагааны улмаас хууль ёсны эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн бол иргэн, хуулийн этгээд нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрт энэ хуульд заасан журмын дагуу гомдол гаргаж болно. Гэмт хэрэгт сэрдэгдэн баривчлагдсан буюу цагдан хоригдсон этгээд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхэд гомдол гаргасан бол баривчлах болон цагдан хорих байрны захиргаа 24 цагийн дотор хаягаар нь хүргүүлэх үүрэгтэй. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн шийдвэр, үйл ажиллагааны талаарх гомдлыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд гаргаж болно.

2. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай 22 дугаар зүйлд:

- а/ Хоригдсон этгээд нь төрийн болон нутгийн захиргаа, бусад байгууллага, албан тушаалтанд явуулах өргөдөл, санал, гомдлоо хорих байрны захиргаагаар дамжуулан илгээнэ.
- б/ Шүүх, прокурор болон хорих байрны үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий төрийн бусад байгууллагад явуулах өргөдөл, санал, гомдлыг хорих байрны захиргаа хянаж шалгаж болохгүй бөгөөд өргөдөл, санал, гомдлыг хүлээн авсан өдрийн дараагийн өдрөөс хэтрүүлэхгүйгээр битүүмжилсэн дугтуйгаар зохих байгууллагад илгээнэ.
- в/ Энэ хуулийн 22.2-т зааснаас бусад төрийн байгууллага, албан тушаалтан, түүнчлэн өмгөөлөгчид хаягласан өргөдөл, санал, гомдлыг хорих байрны захиргаа хянаж, хүлээн авсан өдрөөс хойш гурав хоногийн дотор илгээнэ гэж заасан.

3. 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн үйлдсэн гэмт хэрэг, эрүүдэн шүүсэн тухай гомдол мэдээллийг Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба хүлээн авч шалгаж байхаар тогтоосон бөгөөд өнөөдөр тус албаны үйл ажиллагаа жигдэрч хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд ажиллаж байна. Тус алба нь үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойшх хугацаанд буюу 2002–2009 оныг хүртэлх 7 жилийн хугацаанд иргэдээс эрүүдэн

шүүсэн буюу эрүүдэн шүүх хэлбэрээр үйлдэгдсэн гэмт хэргийн шинжтэй 132 гомдол, мэдээлэл хүлээн авч зохих шалгалтыг явуулсан байна.

Нийт гомдол мэдээллийн 25 хувь буюу 33 тохиолдлыг гэмт хэргийн шинжтэй гэж үзэж эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан байх ба үүний 30 хувь буюу 10 хэргийг шүүхэд шилжүүлэн шийдвэрлэсэн бөгөөд үлдэх хувь нь хуульд заасан үндэслэл журмын дагуу зохих үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон байна. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах чиг үүрэг бүхий байгууллагуудад эрүүдэн шүүгдсэн хэмээх эмэгтэйчүүд, арьс өнгө, шашин болоод бусад цөөнхийн хүмүүстэй тусгайлан харьцахаар бэлтгэгдсэн ажилтан байдаггүй бөгөөд ийм бодит шаардлага, манай улсад байхгүй байна.

#### **14 дүгээр зүйл**

Хохирол төлүүлэх

Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын иргэн бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 120 дугаар зүйлд эрүүгийн хэрэгт иргэний нэхэмжлэл гаргасан бол хохирлын хэмжээ, түүнийг арилгах арга, үндэслэл, нөхцөлийг Монгол Улсын Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хуулиар тодорхойлно, Иргэний хуулийн 497.1–д бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/–ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй, 498.2–т хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/–ийн улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцан арилгана гэж тус тус заасан. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дөчин дөрөвдүгээр бүлэгт /388–397 дугаар зүйл/ эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах талаар тодорхой заасан.

Тухайн хуульд “эрүүдэн шүүгдсэн этгээд хохирлоо арилгуулах” гэж цохон заагаагүй ч хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүх ажиллагааны явцад иргэнийг хууль бусаар ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн, эмнэлгийн байгууллагад байлгасан, албадан эмчлэх арга хэмжээ хэрэглэсний улмаас учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн гэм бурууг үл харгалзан төр хариуцан арилгахаар тусгасан болно. Хуулийн холбогдох зүйлүүдэд хохирол арилгуулах эрх, хохирлыг нөхөн төлүүлэх үндэслэл, эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлөх, сэтгэл санааны хохирлын үр дагаврыг арилгах, цол, шагналыг сэргээх, хуулийн этгээдэд хохирлыг нөхөн төлөх, хууль зөрчсөн ажиллагааны тухай лавлагаа өгөх, хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг тайлбарлах, хохирлыг арилгуулах тухай нэхэмжлэл гаргах, хохирол арилгуулах тухай өргөдлийг хянан шийдвэрлэх талаар тус тус заасан. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүх, прокурорын хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг Засгийн газрын нөөц сангаас гаргах, энэ талаар шүүхийн шийдвэрт тусгаж байхаар Улсын дээд шүүхийн



тайлбар гарсны дагуу эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хохирсон иргэдийн хохирлыг төлөх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар тухай бүр хэлэлцэн шийдвэрлэж байна.

Тухайлбал, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүх, прокурорын хууль зөрчсөн ажиллагааны улмаас хохирсон 20 гаруй иргэд, байгууллагын 500 гаруй сая төгрөгийн хохирлыг Засгийн газрын нөөц сангаас гаргаж барагдуулах арга хэмжээ авлаа. Мөн төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан хохирлыг барагдуулах зориулалтаар 3,4 тэрбум төгрөгийг 2009 оны улсын төсөвт тусгаж урьд жилүүдэд хуримтлагдсан иргэний нэхэмжлэлтэй төрөөс барагдуулах хохирлын асуудлыг нэг мөр шийдвэрлэх ажлыг зохион байгуулж эхлээд байна.

### **15 дугаар зүйл**

#### **Нотлох баримт**

Гэмт хэргийн нөхцөл байдлын талаар хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан баримт сэлт, мэдээллийг нотлох баримт гэж тооцохоор хуульд заасан.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 79 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх талаар хуульд заасан журмыг баримтлаагүй буюу зөрчсөн бол эдгээр нь нотлох чадвараа алдах бөгөөд шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй. Нотлох баримтыг цуглуулахдаа иргэний амь нас, эрүүл мэндэд аюултай, эсвэл тэдний нэр төрийг гутаан доромжлох, хүнлэг бус, хэрцгий харьцах, айлган сүрдүүлэх, мэдүүлэг, тайлбар, дүгнэлт гаргуулахаар тулган шаардах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэхийг хориглосон. Эрүүгийн хуулийн 256 дугаар зүйлд хүч хэрэглэх, эд хөрөнгийг нь устгахаар заналхийлэх, шан харамж өгөх зэргээр гэрч, хохирогчоор худал мэдүүлэг өгүүлсэн, шинжээчээр худал дүгнэлт гаргуулсан, орчуулагчаар худал орчуулуулсан, хэлмэрчээр худал хэлмэрчлүүлсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуугаас гурван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж заасан байна. Өөрөөр хэлбэл хууль бус арга хэрэгслээр цуглуулсан нотлох баримтаар хүнийг шийтгэхгүй байх зарчим манай Улсын Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тусгагдан хэрэгжиж байна.

### **16 дугаар зүйл**

#### **Эрүү шүүлт тулгахыг хориглох**

1. Монгол Улс 2002 онд эрх зүйн шинэчлэл хийхдээ Конвенцийн 16 дугаар зүйлийг хэрэгжүүлж, Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль, тэдгээртэй холбогдуулан гарсан журам, зааварт дараах заалтуудыг тусгажээ.

Эрүүгийн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төр, алдар хүндийг нь гутаах зорилго, хэлбэр агуулж болохгүй” гэж заасан.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч гэмт хэрэгт сэрдэн баривчилж болохгүй”, 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Прокурор, шүүгчийн зөвшөөрөлгүйгээр хэнийг ч шинжилгээ хийлгэхээр эмнэлгийн байгууллагад байлгах, шүүгчийн зөвшөөрөлгүйгээр хэнийг ч цагдан хорихыг хориглоно”, 10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Хэнд ч боловч эрүү шүүлт тулгаж хүнлэг бус хэрцгий хандаж нэр төрийг нь доромжилж болохгүй”, 81 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Сэжигтнээс мэдүүлэг өгөхийг шаардах, түүнтэй хүнлэг бус, хэрцгий харьцах, нэр төрийг нь гутаан доромжлохыг хориглоно” гэж тус тус заасан. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Баривчлагдсан, цагдан хоригдсон этгээдэд эрүү шүүлт тулгах, эсхүл бусад арга хэрэглэн түүний бие махбодийг тарчлаан зовоох буюу сэтгэл санааны дарамтад оруулахыг хориглоно”, 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Хорих байрны ажилтнуудад “хоригдсон этгээдтэй хүнлэг бус харьцах”-ыг хориглосон, 22 дугаар зүйлийн 22.7 дахь хэсэгт “Өөрийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалуулахаар өргөдөл, санал, гомдол гаргасан хоригдож буй этгээдийг хавчин хяхах, мөрдөн мөшгөхийг хориглож ийнхүү хавчин хяхсан, мөрдөн мөшгөсөн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэх”-ээр заасан, мөн, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Хоригдсон этгээдийн амь нас, эрүүл мэндэд тулгарсан, хоригдсон бусад этгээдийн зүгээс түүнд заналхийлсэн, довтолсон тохиолдолд хорих байрны ажилтан хоригдсон этгээдийн хувийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг цаг алдалгүй авах үүрэгтэй” гэсэн байна.

2. “Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял эдэлсэн хүмүүст эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлөхийн зэрэгцээгээр хилсээр хоригдсон хоног тутамд ногдох сэтгэл санааны төлбөрийн хэмжээг тогтоож мөрдүүлэх асуудлыг судалж, санал боловсруулах ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2008 оны 114 дүгээр тушаалаар байгуулсан бөгөөд энэ чиглэлээр тодорхой судалгааны ажлууд хийгдэж байна.

3. НҮБ-ын Эрүүдэн шүүхийн асуудлаарх Тусгай илтгэгч Манфрэд Новакаас 2005 онд Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн зөвлөмжийн с, d хэсэгт “...Хуулийн дагуу баривчлагдсан этгээдийг цагдан хорих зөвшөөрлийг 48 цагийн дотор шүүхээс авах, Цагдан хорих бүртгэл хөтлөлтийг нягт хийх явдлыг хангах” тухай дурдсан.

Энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Баривчлах, цагдан хорих байрны дотоод журам”-ыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар шинэчлэн баталж мөрдүүлэхийн зэрэгцээгээр цагдан хорих байруудад гарч болзошгүй эрүүдэн шүүх явдалд хяналт тавих, түүнээс урьдчилан сэргийлэх, хоригдогчдоос гаргасан санал, гомдол, хүсэлтийг шуурхай шийдвэрлэх зорилгоор Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурорууд 2008 оны 1 дүгээр сараас эхлэн Цагдан хорих төв “Ганц худаг”-д 4 ээлжээр 24 цагийн хугацаагаар ажиллаж байна. Түүнчлэн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58, 59 дүгээр зүйлүүдэд зааснаар баривчлах тогтоолтой этгээдийг дагуу цагдаагийн ажилтныг байлцуулан хүлээн авч, баривчлах хугацаа дууссан, цагдан хорих тухай шүүгчийн захирамж ирээгүй бол цагдан хорих байрны даргын тогтоолоор суллаж байна. 2007 онд баривчлах тогтоолоор 3268 сэжигтнийг баривчлах байранд хүлээн авч, 2075 хүнийг суллаж байсан бол 2008 онд баривчлах тогтоолоор 3487 сэжигтнийг

баривчлах байранд хүлээн авч 1478 хүнийг холбогдох хуулийн дагуу суллажээ. Эдгээр ажиллагаанд прокурор байнгын хяналт тавьж ажиллаж байна.

4. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд эрүүдэн шүүх аливаа илрэлтэй тэмцэх нь прокурорын байгууллагын чиг үүрэгт хамаарах ажил тул дээрх төрлийн зөрчлийг гаргуулахгүй байхад анхаарлаа хандуулж зохион байгуулалтын тодорхой арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна. Эрүүгийн хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг баривчлах, цагдан хорих, байцаах үндэслэл журмыг баримтлах нь хүний эрхийг хангах, хамгаалахад чухал ач холбогдолтой тул Улсын Дээд шүүхтэй хамтран сэжигтнийг баривчлах, сэжигтэн яллагдагчийг цагдан хорих болон хорьж мөрдөх хугацааг сунгах ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нараас гаргаж байгаа алдааг судалж, уг ажиллагааны явцад зөрчил гаргуулахгүй байх, дээрх ажиллагааг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нийцүүлэн явуулах, шуурхай байдлыг хангах зорилгоор “Баривчлах, цагдан хорихтой холбогдсон зарим ажиллагааг зохицуулах тухай журам” боловсруулж гарган нийт хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчээр мөрдүүлэн ажиллаж байна. Уг журамд хойшлуулшгүй тохиолдолд сэжигтнийг шууд баривчилсан бол тогтоолыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь тогтоол үйлдсэнээс хойш 24 цагийн дотор өөрийн биеэр прокурор болон шүүгчид хүргэн өгөхөөр зааж өмнө нь хойшлуулшгүй гэсэн үндэслэлээр баривчлаад орхидог байсан зөрчлийг арилгуулж байна.

Мөн насанд хүрээгүй этгээдийг баривчилсан, цагдан хорьсон тухай түүний эцэг, эх, хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид 12 цагийн дотор танилцуулж мэдэгдэх үүргийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид хариуцуулсан.

Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албанд 2007 оны байдлаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нараас зодож дарамтлах, айлган сүрдүүлэх, хуурч мэхлэх зэргээр мэдүүлэг өгөхийг албадсан, хуурамч мэдүүлэг авсан гэх үндэслэлээр 7 эрүүгийн хэрэг үүсгэгдэн шалгагдсан бол 2008 онд энэ үндэслэлээр 4 эрүүгийн хэрэг үүсгэн шалгажээ. 2007, 2008 оны байдлаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 248 дугаар зүйлд заасан “Илт гэм буруугүй хүнийг сэжигтнээр тооцох, яллагдагчаар татах, ял шийтгэх” 249 дүгээр зүйлд заасан “Хүнийг хууль бусаар баривчлах” гэмт хэрэг үйлдэгдээгүй байна.

5. Прокурорын хяналтад байгаа болон шүүхээр таслан шийдвэрлэгдсэн эрүүгийн хэрэгт сэжигтэн, яллагдагч, гэрч, хохирогч, орчуулагчийн гаргасан мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, орчуулга эргэлзээтэй, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа хуульд заасан үндэслэл журмын дагуу явагдаагүй талаар хангалттай баримт байвал прокурор мөрдөн шалгах ажиллагаа үүсгэн эрүүгийн хэрэгт байцаан шийтгэх ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулж, хэргийг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоохын тулд хэргийн нотлох баримтыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу бүрдүүлэх ажиллагааг зохицуулсан “Мөрдөн шалгах ажиллагаа явуулах аргачилсан заавар”-ыг энэ оны эхэнд шинэчлэн боловсруулсан нь мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгчээс явуулсан хууль бус ажиллагааг илрүүлэн тогтоох, таслан зогсооход чиглэгдэж байна.

6. Улсын Ерөнхий Прокурор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2006 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 347, 1/173 дугаартай тушаалаар “Цагдан

хоригдсон этгээдийг өрөө шилжүүлэх тухай журам”-ыг батлан гаргасан бөгөөд энэ журмаар сэжигтэн, яллагдагчийг өрөө дамжуулан хорих зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд зөвхөн прокурорын зөвшөөрлийг үндэслэн өрөөг нь солих болгосноор үндэслэлгүйгээр өрөө дамжуулан хорьж сэжигтэн, яллагдагчийг ямар нэгэн хэлбэрээр эрүүдэн шүүж байсан үйлдлийг таслан зогсоох арга хэмжээ авснаар хүний эрх, эрх чөлөөг тодорхой хэмжээнд хангаж байна гэж үзэж байна.

Улсын Ерөнхий прокурорын газраас “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах цагдан хорих байр”-ны үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар шалгахад үйл ажиллагаа явуулж байгаа нийт 25 цагдан хорих байрны хоёроос бусад нь шаардлага хангаж байсан ба хоригдогчтой зүй бусаар харьцах зөрчил Сэлэнгэ аймгийн цагдан хорих байрнаас бусад газарт гараагүй байна.

7. Ноён Манфред Новак нь 2005 онд Монгол Улсад айлчлах хугацаандаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа зарим хорих анги, цагдан хорих байрны үйл ажиллагаатай танилцан дүгнэлт, зөвлөмж ирүүлсний дагуу өнгөрсөн хугацаанд тус Ерөнхий газраас дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.

1) Хорих ангиудын хамгаалалтын хашааг нэгдсэн загвар, стандартаар барихаар төлөвлөн 2007 онд 10 ангийг 5.5–6.5 м өндөр, 0.4–0.6 м өргөнтэй цементэн блокон хашаатай, 2008 онд 2 хорих ангийн хамгаалалтын бүсийг ийм хэмжээний хашаатай болгосон. Түүнчлэн нийт 10 гаруй хорих ангид нийт 3500 гаруй ялтан амьдрах шинэ байрыг ашиглалтад орууллаа. Эдгээр байрууд нь нэг өрөөндөө 6–8-аар амьдрах, давхар бүртээ ариун цэвэр, бие засах өрөөтэй, халуун устай хийсэн нь хуульд заасан шаардлага, олон улсын жишигт нийцэж байгаа юм. Мөн бусад хорих ангиудад ялтны байр, номын санг бүрэн засварласан.

Монгол улсад жилд дунджаар 6000 орчим хүн хорих ял эдэлдэг ба тэдгээрийн 3500 буюу 50 орчим хувь нь шинэ байранд ял эдлэх бололцоогоор хангагдлаа.

2) “Баривчлах, цагдан хорих байрны дотоод журам”-ыг шинэчлэн боловсруулж Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2007 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн 78 дугаар тушаалаар батлуулан өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Энэхүү журмын дагуу баривчлах байр, цагдан хорих байруудад хоригдох этгээдийг авчирсан цагдаагийн ажилтныг байлцуулан хүлээн авч, эмчийн үзлэгт хамруулж, тэмдэглэл үйлдэн хувийн хэрэгт хавсаргаж хэвшсэн ба хоригдсон этгээдийг 14 хоног тутамд эмчийн үзлэгт тогтмол оруулж байна.

Цагдан хорих байруудын хэмжээнд өрөөний гэрэлтүүлэг, агааржуулалтыг нэмэгдүүлэх, нэг хүнд ногдох талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор зарим цагдан хорих байруудыг өргөтгөх, засч сайжруулах ажлыг ч мөн дэс дараатай авч хэрэгжүүлж байна. Өнгөрсөн хугацаанд Төв аймаг дахь цагдан хорих байрыг өргөтгөн, өрөөнүүдийг цэвэр, бохир усны шугамд холбон, агааржуулалт, гэрэлтүүлгийг нэмэгдүүлэн, хоригдогчийн орыг шаланд бэхлэн давхарлаж, нэг хүнд 2.5 м<sup>2</sup> -аас багагүй талбай ногдохоор шинэчлэн засварласны зэрэгцээ Дархан –Уул аймаг дахь шийдвэр гүйцэтгэх албаны цагдан хорих байрыг мөн бүрэн засварлалаа.

3) 2008 оны 2 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар өмнөх Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцож байсан 8

зүйл, хэсгийг гэмт хэрэгт тооцохгүй болгож, зарим төрлийн гэмт хэрэгт оногдуулах ялын дээд ба доод хэмжээг багасгасан, энэхүү өөрчлөлтийг хэрэгжүүлэх арга хэмжээнд 2063 ялтан хамрагдсанаас шүүгчийн захирамжаар 705 нь суллагдаж, 611 ялтны ялаас 2–10 хүртэл жил хасагдаж, 747 ялтны ял эдлэх дэглэмийг бууруулжээ.

4) Гянданд өнөөдрийн байдлаар 50 ялтан ял эдэлж байгаа бөгөөд тэдгээрийн 6 нь цаазаар авах ял шийтгэгдэн амь уучлагдаж, 30 жилийн хугацаагаар ял эдэлж байгаа ба эдгээр ялтнууд хууль, журамд заасан эрхээр хангагдаж, гадаад хэл, компьютерийн сургалтад хамрагдаж байгаагийн зэрэгцээ ахуй хангалтыг нь нормын дагуу олгож байна.

Улаан загалмайн нийгэмлэгийн олон улсын хорооны дарга Тиери Мейрат, мөн хорооны мэргэжилтэн шинжээч Хернан Реез нарын төлөөлөгчид 2008 оны 11 дүгээр сард Нэгдсэн хорих 401 дүгээр анги, Насанд хүрээгүйчүүдийн хорих анги, сүрьеэгийн эмнэлэг, Төв аймаг дахь цагдан хорих байрны нөхцөл, хоригдогчдын эрхийн байдалд хяналт хийж, үйл ажиллагаатай танилцан, олон улсын жишигт нийцсэн байна гэсэн дүгнэлт өгсөн болно.

5) Тогтоол гүйцэтгэх газрын харьяанд сургалт, нийгмийн ажлын тасгийг өргөтгөн зохион байгуулж орон тоог нэмэгдүүлэн, үйл ажиллагааг нь эрчимжүүлэхэд анхааран ажиллаж байна. Төвлөрсөн хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтнуудыг чадваржуулах, нийгмийн ажлыг хөгжүүлэхэд чиглэгдсэн 2008–2009 онд хоригдогсдыг нийгэмшүүлэх ажлын хөтөлбөрийг боловсруулан гаргаж алба, хорих ангиудад хүргүүлэн хэрэгжилтийг зохион байгуулж байна. Иргэний бүртгэл мэдээллийн улсын төвтэй хамтран нийт ялтнуудыг суллагдахаас нь өмнө иргэний үнэмлэхтэй болгохоор шийдвэрлэсэн бөгөөд холбогдох материалыг нь бүрдүүлэн 52 ялтанд иргэний үнэмлэх олгосон байна. Ялтныг нийгэмшүүлэх ажлын хүрээнд зарим хорих ангиудыг түшиглэн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв байгуулах бэлтгэл ажлыг ханган, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас “Мэргэжлийн түр сургалт явуулах зөвшөөрөл”-ийг авч, Амгалан дахь хорих 421, Говьсүмбэр дэх хорих 425 дугаар ангиуд, Дархан–Уул аймаг дахь шийдвэр гүйцэтгэх албанд барилгын засал чимэглэл, өрөгч, угсрагчийн чиглэлээр нийт 95 ялтанд мэргэжил олгох сургалтыг эхлүүлээд байна.

Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар батлагдсан “Хорих ангийн дотоод журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт “Албан хаагчийн зүгээс ялантай энгийн иргэдийн адил харьцана”, мөн зүйлийн 7.2 дахь хэсэгт “Ялтныг ял шийтгэл, арьс өнгө, яс үндэс, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол зэргээр ялгаварлан харьцахыг хориглоно” гэж тус тус заасан нь Конвенцийн агуулгад нийцэж байна.

Конвенцийн 16 дугаар зүйл болон Монгол Улсын хуулиудад заасан эрүүдэн шүүхээс бусад хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх хэлбэрүүд нь төрийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтнаас гарсан эсэх, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж шүүхээр шийтгэгдсэн байдал, түүнчлэн сахилгын шийтгэл хүлээсэн байдлыг судлах зорилгоор Улсын ерөнхий прокурор, Улсын дээд шүүх, Цагдаагийн ерөнхий газар, Батлан хамгаалах яам, Хил хамгаалах ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Боловсрол шинжлэх ухааны яам, Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба зэрэг байгууллагад хандахад дараах байдал тогтоогдож байна. Үүнд:

1. Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албанаас ирүүлсэн сүүлийн 4 жилийн судалгаанаас үзвэл хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон шүүх, прокурорын байгууллагын ажилтнуудаас хэргийн холбогдогч, сэжигтэн, яллагдагчтай хүнлэг бус харгис хэрцгий хандсан тухай нийт 1708 өргөдөл гомдол ирснийг шалгасны үндсэн дээр 19 ажилтанд холбогдох 12 хэрэгт хэрэг бүртгэлт хийж 6 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр прокурорт шилжүүлжээ.
2. Батлах хамгаалах яамнаас ирүүлсэн судалгаагаар тус яамны хэмжээнд 2001–2004 он, 2005 оны эхний 5 сарын байдлаар цэргийн албан хаагчдаас дүрмийн бус харьцаа гаргаж гэмт хэрэгт холбогдсон 29 тохиолдол бүртгэгдсэн байна. Тухайлбал, 2005 оны эхний 5 сарын байдлаар Батлан хамгаалахын Их сургуульд харуул ротын байлдагч Б, Н, А, М, Ш нарын 8 байлдагч Б, М, С нарыг бүлэглэн зодож бие махбодид нь гэмтэл учруулсан, Зэвсэгт хүчний 186, 326 дугаар ангиудын салбарын захирагч, ахлах дэслэгч Т, Б нар захирагдагсдаа зодож хөнгөн болон хүндэвтэр гэмтэл учруулсан гэмт хэрэг үйлдэгджээ.
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хэмжээнд сэжигтэн, яллагдагч, ялантай зүй бус харьцсан асуудал гарч байсныг тухай бүр нь илрүүлэн ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулж байсны зэрэгцээ сэжигтэн, яллагдагч, ялтны өргөдөл гомдлоор прокурор, цагдаагийн байгууллага, эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж шийдвэрлэжээ. Тухайлбал, сэжигтэн, ялантай зүй бус харьцаж биед нь гэмтэл учруулах зөрчлийг 2004 оны хэмжээнд 15 албан хаагч гаргаснаас 11 албан хаагч ажил мэргэжилдээ тэнцэхгүйн улмаас халагдсан бол 4 албан хаагчид тодорхой төрлийн сахилгын зөрчил ногдуулж, 3 албан хаагчид эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан бөгөөд 2 албан хаагч шүүхээр шийтгүүлж, 1 албан хаагчийн хэргийг хэрэгсэхгүй болгосон бол 2005 онд 5 албан хаагч дээрх зөрчлийг гаргаснаас, 1 албан хаагч халагдаж, 1 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан, 2006 онд 2 албан хаагч гаргаснаас, 1 албан хаагч халагдаж, 1 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан, 2007 онд 2 албан хаагч гаргаснаас, 1 албан хаагч халагдаж, 1 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан, 2008 онд 4 албан хаагч гаргаснаас 1 албан хаагч халагдаж, 1 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулж, 2 албан хаагчид эрүүгийн хэрэг үүсгэн шалгагдаж байсан ба 1 албан хаагчийн хэргийг хэрэгсэхгүй болгож 1 албан хаагч шалгагдсаар байгаа мэдээ байна.

## **7.2 ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР БУЮУ ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦИЙН ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН АНХДУГААР ИЛТГЭЛИЙГ ХЭЛЭЛЦЭЖ ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН ЭСРЭГ ХОРООНООС МОНГОЛ УЛСАД ӨГСӨН ЗӨВЛӨМЖ**

### **Монгол Улс**

1. 2010 оны 11 дүгээр сарын 5, 8–ны өдөр Монгол Улсын анхдугаар илтгэл (CAT/C/MNG/1)–ийг Хороо 963, 964 дэх хурлаараа хэлэлцээд 976 дахь хурлаараа дараах зөвлөмжийг баталлаа.

### **А. Танилцуулга**

2. Хороо нь Монгол Улсын өргөн барьсан анхдугаар илтгэлийг талархан хүлээн авч байгаа ч Хорооны баталсан илтгэл боловсруулах удирдамжийг баримтлаагүй байгааг анхааруулж байна. Илтгэл Конвенцийн хэрэгжилтийн талаарх статистик тоо баримт болон практик мэдээллээр дутмаг байна. Анхдугаар илтгэлийг 6 жилийн өмнө өргөн барих ёстой байсан боловч ийнхүү хоцроож өргөн барьсанд Хороо харамсаж байна. Энэ хугацаанд Хороо нь Оролцогч улс дахь конвенцийн хэрэгжилтийн байдалд хяналт шинжилгээ хийж чадаагүй. Түүнчлэн илтгэл боловсруулахад иргэний нийгмийн нэг ч байгууллагыг оролцуулаагүйд Хороо харамсаж байна.

3. Оролцогч улсын төлөөлөгчид бидэнтэй илэн далангүй, үр өгөөжтэй ярилцлага өрнүүлсэнд мөн Хорооны гишүүдийн асуултад дэлгэрэнгүй хариу амаар өгсөнд Хороо талархаж байна. Энэ бүхэн Хороонд ач холбогдолтой нэмэлт мэдээлэл өгсөн билээ.

### **Б. Эерэг тал**

4. Оролцогч улс Конвенцид 2002 оны 1 дүгээр сарын 24–ний өдөр нэгдэн орсноос хойш дараах олон улсын гэрээ хэлэлцээрт нэгдэн орсон байгааг Хороо талархан хүлээн авч байна. Үүнд:

- a) Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн Нэмэлт протокол (2002 оны 3 дугаар сард нэгдэн орсон),
- b) Олон Улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрэм (2002 оны 4 дүгээр сард),
- c) Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол (2003 оны 6 дугаар сард),
- d) Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг конвенцийн нэмэлт протокол (2004 оны 10 дугаар сард),
- e) Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ–ын конвенц, түүний протоколууд (2008 оны 5 сард),
- f) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц (2009 оны 5 дугаар сард),

- g) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн Нэмэлт протокол (2009 оны 5 дугаар сард),
- h) Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын Пактын нэмэлт протокол (2010 оны 7 дугаар сард).
5. Хүний эрхийг илүү сайн хамгаалахын тулд хууль тогтоомжоо байнга шинэтгэж буй Оролцогч улсын хүчин чармайлтыг Хороо тэмдэглэж байна. Тухайлбал:
- a) 2002 онд батлагдсан Эрүүгийн хууль,
  - b) 2005 онд батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль,
  - c) 2007 оны 8 дугаар сарын 3-нд батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль,
  - d) 2008 оны 2 дугаар сарын 1-нд батлагдсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль.
6. Хүний эрхийг илүү сайн хамгаалахын тулд Оролцогч улс шинэ бодлого баримталж, арга хэмжээг авч хэрэгжүүлж байгааг Хороо талархан тэмдэглэж байна. Тухайлбал:
- a) “Монгол Улсад Хүний эрхийн эрхийг хангах Үндэсний хөтөлбөр”-ийг 2003 онд баталсан бөгөөд 2005 онд Үндэсний хөтөлбөрийн ажлын албыг байгуулсан,
  - b) 2004 оноос эхлэн тусгай мандаттай хүмүүст байнгын урилга өгч эхэлсэн,
  - c) “Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг Үндэсний хөтөлбөр”-ийг 2007 онд баталсан,
  - d) “Бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүүхэд эмэгтэйчүүдийг худалдаалахаас урьдчилан сэргийлэх Үндэсний хөтөлбөр /2005–2015/”-ийг баталсан,
  - e) Эрүү, иргэн, захиргааны хэргээр хууль зүйн зөвлөгөө өгөх төвийг Нийслэл хотын бүх дүүрэг болон 21 аймагт байгуулсан,
  - f) Цаазаар авах ялыг түр түдгэлзүүлэх тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн тунхаглал.

## **В. Анхаарал татаж буй гол асуудлууд ба холбогдох зөвлөмж**

### **“Эрүүдэн шүүх” нэр томъёоны тодорхойлолт ба зүйлчлэл**

7. “Эрүүгийн хууль болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг олон улсын баримт бичиг, конвенцид нийцүүлэхийн тулд 2008 онд тэдгээрт тодорхой нэмэлт, өөрчлөлт оруулсан”-ыг Хороо тэмдэглэхийн сацуу Хүний эрхийн зөвлөлийн Эрүүдэн шүүхийн Тусгай илтгэгчийн 2006 онд цохон тэмдэглэсэнчлэн Конвенцийн 1 дүгээр зүйлтэй нийцсэн тодорхойлолт Монгол Улсын хууль тогтоомжид байхгүй байгаад санаа зовиож байна. (1, 4 зүйл)

Оролцогч улс нь Конвенцийн 1 дүгээр зүйлд нийцүүлэн “эрүүдэн шүүх”-ийн тодорхойлолтыг дотоодын эрүүгийн хууль тогтоомждоо тусгах хэрэгтэй байна. Түүнчлэн Конвенцийн 4 дүгээр зүйлд нийцүүлэн эрүүдэн шүүх гэмт хэргийг эрүү шүүлт тулгахаас салгах, түүнчлэн гэмт хэргийн хүнд хөнгөнөөс хамаарч ял ноогдуулах талаар хууль тогтоомждоо тусгах хэрэгтэй.

### **Эрх зүйн үндсэн хамгаалалт**

8. Баривчлах, цагдан хорих асуудал байнга гардаг тухай мэдээлэл Хорооны анхаарлыг татлаа. Шүүх хурлаас өмнө цагдан хорьсон нийт тохиолдлын гуравны хоёр нь



шүүхийн шийдвэргүй байжээ. Мөн сэжигтэн баривчлагдмагцаа шүүгч, өмгөөлөгч, эмч, гэр бүлийнхэнтэйгээ хуульд заасны дагуу уулзах боломжгүй байгаад харамсаж байна. Түүнчлэн цагдан хорих арга хэмжээг эцсийн шатанд авах ёстой байтал юу юуны түрүүнд авах гээд байдаг нь Хорооны анхаарлыг татлаа.

Цагдан хоригдож эхэлсэн анхны өдрөөс эхлэн цагдан хоригдогчийг эрх зүйн бүхий л хамгаалалтаар хангахад Оролцогч улс түргэн шуурхай, үр нөлөөтэй арга хэмжээ авах хэрэгтэй. Тухайлбал цагдан хоригдох болсон шалтгаанаа мэдэх, шаардлагатай үедээ өмгөөллийн үйлчилгээ болон хууль зүйн туслалцаа цаг алдалгүй авах зэрэг цагдан хоригдогчийн эрхийг хамгаалах шаардлагатай. Мөн цагдан хоригдогчийн өөрийн сонгосон эмчдээ ганцаарчлан үзүүлэх, гэр бүлийнхэнтэйгээ холбогдох, хэргээ шүүхээр түргэн шийдвэрлүүлэх, хууль ёсоор цагдан хоригдсон эсэхээ шүүхээр шалгуулах зэрэг эрхийг олон улсын стандартын дагуу эдлүүлэх шаардлагатай байна.

### **Эрүүдэн шүүх үйлдэл гаргагчид ял завшиж байна**

9. Эрүүдэн шүүх, зүй бусаар харьцсан үйлдлийнх нь төлөө хууль сахиулах байгууллагын ажилтан болон мөрдөн байцаагчдыг тухай бүрт нь мөрдөн шалгаж, хангалттай шийтгээд байдаггүйд Хороо санаа зовинож байна. Үүнийг Хүний эрхийн зөвлөлийн эрүүдэн шүүхийн Тусгай илтгэгч мөн адил хөндсөн бөгөөд тэрбээр “ял завших явдал нь эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах явдлын үндсэн шалтгаан юм” гэж хэлсэн байдаг. Түүнчлэн тэрбээр эрүүдэн шүүх асуудал цагдаагийн газар, цагдан хорих төвүүдэд голчлон тохиолдохоос гадна “эрүүдэн шүүх”-ийн талаарх ойлголт, тодорхойлолтыг Конвенцид нийцүүлэн Эрүүгийн хуульд тусгаагүй, энэ талаар ирсэн гомдлыг хүлээн авч, мөрдөн шалгах үр дүнтэй механизмгүйгээс тус тус болж энэ төрлийн гэмт хэрэг ял завшиж байна” гэж дүгнэсэн. (1, 2, 4, 12,16 дугаар зүйл)

Ял завших явдлыг зогсоож, эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах явдал гаргасан төрийн албан хаагчийг буруушааж, ийм үйлдэл хийсэн хэнийг ч бай мөрдөн шалгаж, шаардлагатай бол яллах, шүүх, үйлдсэн гэмт хэргийнх нь хүнд, хөнгөнд нь таарсан ял ногдуулж байхыг Оролцогч улсаас хүсч байна. Оролцогч улс нь эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах явдал гаргагчдыг ял завшихаас сэргийлэх үүднээс үр дүнтэй, хараат бус мөрдөн шалгах механизм байгуулах хэрэгтэй байна. Эрүүгийн хуулийн 44.1–т “Заавал биелүүлэх тушаал, захирамжийг биелүүлэхдээ энэ хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд гэм хор учруулсан бол гэмт хэрэгт тооцохгүй” гэж заасныг нэн даруй хүчингүй болгох шаардлагатай. Дээд шатны албан тушаалтны тушаал эрүүдэн шүүх аливаа үйлдлийг зөвтгөх шалтаг болохгүй гэсэн агуулгаар Оролцогч улс хууль тогтоомжоо өөрчлөх нь зүйтэй.

### **2008 оны 7 дугаар сарын 1–ний үйл явдлыг үеэр зүй бусаар хандаж их хэмжээгээр хүч хэрэглэсэн нь**

10. Сүхбаатарын талбай дээр 2008 оны 7 дугаар сарын 1–ний өдөр болсон жагсаал цуглаан болон онцгой байдлын үеэр цагдаагийн байгууллага шаардлагагүй, их хэмжээний хүч хэрэглэсэнд сэтгэл хангалуун бус байна. Илтгэлд дурдсанчлан эдгээр шаардлагагүй, их хэмжээний хүчийн ихэнхийг онцгой байдал зарласны дараа

хэрэглэсэнд Хороо зовинож байна. Түүнчлэн Хүний эрхийн Үндэсний Комиссын хийсэн судалгааны дүнд сэтгэл хангалуун бус байна. Учир нь судалгаагаар цагдан хоригдсон 100 хүнтэй ярилцахад тэдний 88 нь баривчилгаа, мөрдөн байцаалтын үеэр цохиулж, дайрч доромжлуулсан гэж хариулсан байна. Цагдан хоригдсон хүмүүс даац нь хэтэрсэн байранд олноороо хоригдсон, 48–72 цаг хоол ундгүй, ариун цэврийн өрөө ашиглаагүй, өмгөөлөгч, гэр бүлийнхэнтэйгээ уулзах боломжгүй байсанд Хороо түгшинэ. (2, 12, 16 дугаар зүйл)

Зэвсэг хэрэглэх заавар, удирдамж маш тодорхой байх, шаардлагагүй байхад зэвсэг хэтрүүлэн хэрэглэвэл хүлээлгэх хариуцлагыг хууль сахиулах байгууллагын ажилтнуудад сайн ойлгуулсан байхыг Оролцогч улсад зөвлөж байна. Аливаа арга хэмжээ авахад одоогийн хууль тогтоомжийн дагуу авч байх шаардлагатай. Тухайлбал онц байдал зарлахдаа эрх бүхий этгээд хуульд заасан журмын дагуу зарладаг байх шаардлагатай байна. Оролцогч улсын хууль хяналтын байгууллагын ажилтнууд хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан аливаа хууль тогтоомжийг хэрэгжүүлэхдээ баривчилгааны үе дэх хүний эрхийг хамгаалах үндсэн зарчмууд болон Баривчлагдсан болон ямар нэг хэлбэрээр хоригдож байгаа хүнийг хамгаалах НҮБ–ын Цогц зарчим (Ерөнхий Ассамблейн 1988 оны 12 дугаар сарын 9–ны өдрийн 43/173 тоот тогтоолоор батлагдсан)–ыг чанд баримтлах шаардлагатай байна. Эрх, эрх чөлөө нь хязгаарлагдсан этгээд өмгөөлүүлэх эрх болон эмч, гэр бүлийнхэнтэйгээ уулзах боломжоор хангагдсан байх хэрэгтэй. Ял завших болон эрх мэдлээ хууль бусаар ашиглах явдлыг таслан зогсоох үүднээс буруутай нь тогтоогдсон хууль хяналтын байгууллагын ажилтнуудад эрүүгийн болон захиргааны хариуцлагыг оногдуулж байхыг хүсье.

### **Гомдол, түүнийг шуурхай, хараат бус, үр нөлөөтэй мөрдөн шалгах нь**

11. 2002 оноос ганц хүн хүнлэг бус, харгис үйлдлийнхээ төлөө яллагдсан ба 2007 оноос 744 хэргээс ганц л хүн шоронд ял эдэлж бусад нь ял завшиж үлдсэн байгаагаас үзвэл хууль зөрчигчдөд ял завших боломж олгож байна гэж Хороо дүгнэж байна. Энэ асуудлыг Хүний эрхийн зөвлөлийн эрүүдэн шүүхийн Тусгай илтгэгч ч мөн хөндсөн байгаа. Тэрбээр “хэдийгээр хохирогч холбогдох этгээдэд хандаж гомдол гаргах эрх зүйн механизм байдаг ч энэ нь амьдрал дээр хэрэгждэггүй ... Эцэст нь эрүүдэн шүүгдэх буюу зүй бус бусад үйлдлийн хохирогч шударга шүүхэд хандах, нөхөн олговор авах, нөхөн сэргээх үйлчилгээг хүртэх боломжгүй болж байна” гэжээ. Түүнчлэн 2008 оны 7 дугаар сарын 1–ний үйл явдлыг дараа нийт 10 гомдол Хүний эрхийн Үндэсний Комисст ирсний 4 нь эрүүдэн шүүх асуудалтай холбоотой байжээ. Мөн Прокурорын ерөнхий газар нийт 11 гомдол хүлээж авсан боловч хангалттай нотлох баримтгүй гэсэн шалтгаанаар хэрэгсэхгүй болсонд Хороо зовинож байна. (2, 12, 13 дугаар зүйл)

Оролцогч улс нь гомдол хүлээж авч шуурхай, хянан шийдвэрлэх хараат бус, үр дүнтэй механизмыг амьдралд нэвтрүүлэх шаардлагатай байна. Түүнчлэн ял завших байдалд шүүмжлэлтэй хандаж, эрүүдэн шүүх, зүй бусаар хандах аливаа үйлдэлд буруутай нь тогтоогдсон этгээдийг цаг алдалгүй яллаж байх хэрэгтэй. Конвенцийн 13 дугаар зүйлд заасны дагуу Оролцогч улс гомдол гаргагч, өмгөөлөгч, гэрчийг айлган сүрдүүлэх, өшөө хонзонгийн бай болохоос нь хамгаалах арга хэмжээ авах шаардлагатай. Эцэст нь 2008 оны 7 дугаар сарын 2–ны өдөр баривчлагдан Дэнжийн мянган Цагдан

хорих төвд хоригдсон Ц.Зандаахүүгийн өргөдөл гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг Хороонд ирүүлнэ үү.

### **Хүний эрхийн Үндэсний Комисс**

12. Хүний эрхийн Үндэсний Комисс нь Парисын Зарчмын дагуу байгуулагдсан “А” зэрэглэлийн статустай ба хүний эрхийн асуудлаар санал гаргах, бусад байгууллагад шаардлага, зөвлөмж өгөх эрхтэй хүний эрхийн үндэсний байгууллага ажээ. Харамсалтай нь Комисс 2008 оны 7 дугаар сарын 1–ний онц байдлын үеэр хүний эрх зөрчигдөөгүй гэсэн мэдэгдэл гаргасанд Хороо харамсаж байна. Комиссын энэхүү мэдэгдэлд үндэслэн шүүх байгууллага эрүүдэн шүүх, зүй бус үйлдлийн талаар ирсэн гомдлуудыг хэрэгсэхгүй болгосон ба хүч хэрэглэн авсан мэдүүлгийг сүүлд сэжигтний эсрэг шүүхэд ашигласан нь Хороог түгшээлээ. (1, 2, 4, 13, 15, 16 дугаар зүйл)

Хүний эрхийн Үндэсний Комиссын удирдлагыг томилох ажиллагааг олонд нээлттэй байлгахаас гадна томилгооны үед иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчдийн оролцоог нэмэгдүүлэх зэргээр ил тод байдлыг хангах шаардлагатай байгааг анхаарна уу. Оролцогч улс нь Үндэсний Комиссын бие даасан байдал, бүрэн эрхийг нь тус тус бэхжүүлэхээс гадна элдэв янзаар үйл ажиллагааг нь хязгаарлахгүй байх хэрэгтэй. Түүнчлэн үйл ажиллагаагаа явуулахад нь шаардагдах хангалттай хэмжээний хүн хүч, хөрөнгө мөнгө, эд материалаар Комиссыг хангана уу. Монгол Улсын хэмжээнд ажиллаж байгаа баривчлах байруудад системтэй, гэнэтийн шалгалт хийх, эрүүдэн шүүхтэй холбоотой өргөдөл гомдлыг авч үзэх, хохирогчдод нөхөн олговор олгосон эсэх, нөхөн сэргээлтэд хамруулсан эсэхийг шалгах зэрэг эрхийг Хүний эрхийн Үндэсний Комисст олгох шаардлагатай байна. Эрүүдэн шүүхийн асуудлаар шүүх, хууль хяналтын байгууллагын ажилчдад сургалт зохион байгуулахдаа Хүний эрхийн Үндэсний Комисстой заавал хамтрах хэрэгтэй. Түүнчлэн хүний эрхийн талаар олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн кампанит ажил зохион байгуулахдаа Комиссыг оролцуулж байна уу.

### **Дүрвэгсдийг албадан гаргахгүй байх үүрэг**

13. Монголын албаны хүмүүс 11 орны нийт 3713 иргэнийг албадан гаргах шийдвэр гаргажээ. Ингэхдээ албадан гаргагдаж байгаа хүн эх нутагтаа эрүүдэн шүүгдэж болзошгүй гэсэн шалтгаанаар түр түдгэлзүүлсэн болон хэрэгжилтийг нь зогсоосон нэг ч шийдвэр байгаагүйд Хороо харамсаж байна. Цаашилбал, эцсийн шийдвэр гараагүй байхад орогнох хүсэлт гаргасан хүнийг гэр бүлийнх нь хамтаар 2009 оны 10 дугаар сард БНХАУ руу албадан гаргасанд Хороо харамсаж байна. (3 дугаар зүйл)

Конвенцийн 3 дугаар зүйлд заасан үүргээ биелүүлэхийн тулд Оролцогч улс хууль тогтоомж, шүүх, захиргааны бүхий л арга хэмжээ авах шаардлагатай байна. Хэдийд албадан гаргахгүй байх вэ гэдгийг тогтоохдоо Оролцогч улс хэрэг тус бүрийн мөн чанарыг сайтар судлах хэрэгтэй. Түүнчлэн албадан гаргах харилцааг зохицуулсан хууль тогтоомждоо өөрчлөлт оруулах нь зүйтэй. Оролцогч улс 1951 оны Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай (1951 оны 7 дугаар сарын 28–нд НҮБ–ын Ерөнхий Ассамблейн баталсан) конвенц болон түүний 1967 оны Протоколд нэгдэж орох хэрэгтэй байна. Олон

улсын дүрвэгсдийн болон хүний эрхийн эрх зүйн талаар сургалтанд хууль хяналтынхан, шилжилт хөдөлгөөний асуудал хариуцсан ажилтнуудыг тус тус хамруулах шаардлагатай. Ингэхдээ албадан гаргахгүй байх зарчмыг онцолж, албадан гаргах шийдвэрийг шүүхэд давж заалдсан бол ажиллагааг түр хойшлуулдаг байх хэрэгтэй.

#### **Шүүх байгууллагын ажилчдын сургалт**

14. Олон улсын эрх зүйн баримт бичиг дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилж байгааг тэмдэглэхийн зэрэгцээ Хороо эдгээр баримт бичгийн талаарх шүүгчдийн мэдлэг хязгаарлагдмал талаарх төлөөлөгчдийн мэдэгдэлд сэтгэл зовинож байна. Энэ талаар Хүний эрхийн зөвлөлийн эрүүдэн шүүх асуудал хариуцсан Тусгай илтгэгч ч “прокурор, өмгөөлөгч, хуульч болон шүүгч нарын эрүүдэн шүүхийг хориглосон олон улсын стандартуудын талаарх суурь мэдлэг дутмаг” гэж дүгнэсэн байдаг. Ялангуяа олон улсын гэрээ, конвенцид үндэслэн үйлчлүүлэгчээ өмгөөлбөл шүүгч илүү хүнд ял өгдөг гэсэн мэдээллийг Хороо авсан.

Конвенц буюу ялангуяа эрүүдэн шүүхийг хориглосон заалтын талаар шүүгч, прокурор, шүүгч, хуульч, өмгөөлөгч болон холбогдох бусад албан хаагчдыг сургалтад заавал хамруулах шаардлагатай байна. Сургалт зохион байгуулахдаа Оролцогч улс олон улсын дэмжлэг авч болно. Төрийн албан хаагч, баривчилгаа, цагдан хорих асуудал хариуцдаг эрүүл мэндийн ажилтан болон хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчдад Истанбулын протокол гэж нэрлэгдсэн Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэсэн үйлдлийг мөрдөн шалгаж, баримтжуулах гарын авлагаар мэргэшүүлэх сургалтад хамруулах хэрэгтэй байна.

#### **Хууль хяналтын байгууллагын ажилтны сургалт**

15. Цагдаагийн ажилтнууд жагсаал цуглааныг хяналтандаа авах, зэвсэг хэрэгсэл ашиглах талаар сургагдаагүй байгаад Хороо харамсаж байна. Мөн тэд энэ нөхцөлд зэвсэг хэрэглэх зааварчилгаагүй байдаг ба зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтэрсэн хүч хэрэглэхийг хориглосон байдаг талаар мэдлэггүй байдаг нь илтгэлээс харагдлаа. (10 дугаар зүйл) Жагсаал, цуглааны байдалд тааруулж зэвсэг хэрэгсэл ашиглах, хүч хэрэглэх, түүнчлэн зэвсэг хэрэгсэл болон хүчийг зөвхөн онцгой тохиолдолд тааруулж хэрэглэх талаарх сургалтад хууль сахиулах байгууллагын ажилтнуудыг хамруулахад Оролцогч улс анхаарах нь зүйтэй. Цагдаагийн ажилтнуудыг НҮБ-ын Хууль сахиулах байгууллагын ажилтнуудын үйл ажиллагааны дүрэм (Ерөнхий Ассамблейн 1979 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 34/169 тоот тогтоолоор батлагдсан) болон НҮБ-ын Галт зэвсэг, хүч хэрэглэхэд баримтлах суурь зарчмууд (1990 оны 8 дугаар сарын 27-оос 9 дүгээр сарын 7-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэнтэй харьцах талаарх НҮБ-ын 8 дугаар Конгрессоос батлагдсан)-д тус тус нийцүүлэн сургах шаардлагатай байна.

#### **Баривчлах байрны нөхцөл**

16. Даац нь хэтэрсэн их хүнтэй, агааржуулалтын болон дулааны систем тааруу, бие засах өрөө болон ус хангамж хангалтгүй, халдварт өвчний тархалт их зэрэг баривчлах

байрны нөхцлийн талаар Хороо санаа зовинож байна. Түүнчлэн баривчлагдсан этгээдийг ялтнуудтай нэг камерт хийх, камерыг нь байнга солих, шоронгийн харгалзагч зарим нэг цагдан хоригдогч /баривчлагдсан этгээдийг дарамтлахаар ялтныг өдөөн турхирах зэрэг зүй бус явдлууд Хорооны анхаарлыг татлаа. 30 жилийн хорих ялтай ялтнуудыг бусдаас тусгаарлаж ганцаарчлан хорьж байна. Зарим нэг ийм хорих ялтай хүмүүс ингэж хоригдсоноос цаазаар авхуулах нь дээр гэж үздэгээ Хүний эрхийн хорооны Эрүүдэн шүүхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгчид хэлж байжээ. Хорооны онцгойлон хөндөж байгаа асуудал бол цаазаар авхуулахаа хүлээж буй хүмүүсийг ганцаарчлан, гав гинжтэй хорьж, хангалттай хоол өгөхгүй байгаа явдал юм. Иймэрхүү нөхцлийн талаар Тусгай илтгэгч мөн адил дурдсан бөгөөд тэрбээр энэ байдлыг нэмэлт ял гэж нэрлэн Конвенцийн 1 дүгээр зүйлд заасны дагуу “эрүүдэн шүүх” үйлдэл мөн гэж дүгнэсэн.

Оролцогч улс ганцаарчлан хорих дэглэмээ устгахыг Хороо зөвлөж байна. Түүнчлэн бүх ялтантай хүнлэг, НҮБ-ын Ялтантай харьцах минимум стандарт (Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 1957 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 663 С (XXIV) тоот тогтоол, 1977 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 2076 (LXII) тоот тогтоолоор тус тус батлагдсан) болон Баривчлагдсан болон ямар нэг хэлбэрээр хоригдож байгаа хүнийг хамгаалах НҮБ-ын Цогц зарчим (Ерөнхий ассамблейн 1988 оны 12 дугаар сарын 9-ны өдрийн 43/173 тоот тогтоолоор батлагдсан)-д тус тус заасны дагуу харьцах хэрэгтэй. Баривчлах байрны нөхцлийг сайжруулж олон улсын стандартад нийцүүлэх ажлаа Оролцогч улс цаашид ч үргэлжлүүлэх шаардлагатай. Шоронгийн харгалзагч болон бусад албан хаагчид хууль, дүрмээ чанд сахин ажиллаж байгаа эсэхийг Оролцогч улс нягтлах хэрэгтэй. Түүнчлэн Прокурорын Ерөнхий Газар, Хүний эрхийн Үндэсний Комисс болон бие даасан бусад байгууллагад баривчлах байранд байнгын гэнэтийн шалгалт хийх эрх олгох нь зүйтэй.

### **Нөхөн олговор**

17. Эрүүдэн шүүх, зүй бус аливаа үйлдлийн хохирогчдыг шударга шүүх, нөхөн олговор, нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах үр дүнтэй, цогц арга хэмжээ аваагүй байгаад Хороо харамсаж байна. Нөхөн олговрыг зохицуулсан Монгол Улсын хууль тогтоомжид эрүүдэн шүүхээс болж хохирсон хохирогчдод нөхөн олговор олгох эрх зүйн үндэс бүрэлдээгүй байгааг Хороо онцолж байна. Үүнийг Монгол Улсад ажиллаад ирснийхээ дараа Тусгай илтгэгч мөн адил хөндсөн юм. /14 дүгээр зүйл/

Оролцогч улс эрүүдэн шүүх үйлдлийн хохирогчдод нөхөн олговор авах боломжоор хангах, тэдэнд шударга, хангалттай нөхөн олговор авах эрх олгох хэрэгтэй. Түүнчлэн эрүүдэн шүүх, зүй бус аливаа үйлдлийн хохирогчдод нөхөн олговор олгох эрх зүйн үндсийг тогтоосон хууль тогтоомж батлах нь зүйтэй.

### **Эрүүдэн шүүж авсан мэдүүлэг**

18. Хорооны маш их зовинож байгаа асуудал бол эрүүдэн шүүж байж авсан мэдүүлгийг Монгол Улсын шүүх өнөөг хүртэл нотлох баримт болгож байгаа явдал юм. Үүнийг Тусгай илтгэгч ч бас хөндсөн. Тэрбээр сэжигтнийг яллахдаа мэдүүлэгт хэт найддаг шүүхийн тогтолцоо нь “эрүүдэн шүүх, зүй бус үйлдлийн эрсдэлийг бодит болгож байна” гэжээ. 2008 оны 7 дугаар сарын 1-ний үйл явдалтай холбогдуулж баривчилсан хүмүүсийг

эрүүдэн шүүж байцаасан бөгөөд ийнхүү замаар авсан мэдүүлгийг шүүхэд нотлох баримт болгон ашигласанд харамсаж байна. (15 дугаар зүйл)

Эрүүдэн шүүх замаар авсан аливаа мэдүүлгийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд ашиглахгүй байхыг Оролцогч улсаас хүсье. Түүнчлэн эрүүдэн шүүх, зүй бус явдал гарах боломжтой газарт дүрс, дуу бичлэгийн техник ашиглаж хяналт тавих, байцаалт бүрийг хальсанд буулгах технологийг амьдралд нэвтрүүлэх, үүнд зориулж хөрөнгө санхүү, хүн хүчээ Оролцогч улс дайчлах шаардлагатай байна. Сэжигтнийг эрүүдэн шүүж, зүй бус замаар авсан нь тогтоогдсон мэдүүлгийг түүний эсрэг нотлох баримт болгон ашиглахгүй байх нөхцлийг Оролцогч улс бүрдүүлэх хэрэгтэй. Харин эрүүдэн шүүсэн, зүй бусаар харьцсан гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээдийн эсрэг хүч хэрэглэн, эрүүдэн шүүж авсан мэдүүлгийг нотлох баримт болгон зайлшгүй эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд ашиглах нь зүйтэй.

### **Цаазаар авах ялтай ялтан болон цаазаар авах ял**

19. Цаазаар авах ял төрийн нууцад хамаардаг, цаазаар авах ялыг гүйцэтгэх өдрийг цаазаар авах ялаар шийтгүүлсэн этгээдийн гэр бүлийнхнээс нууцалдаг, түүнчлэн цаазаар авахуулсан этгээдийн цогцыг гэрийнхэнд нь өгдөггүй зэрэг мэдээлэлд Хороо харамсаж байна. Үүнээс гадна цаазаар авахуулах ялтай 44 хүний хувь заяа, хоригдож байгаа нөхцөлд Хороо санаа зовинож байна.

Оролцогч улс цаазаар авах ялтай холбоотой статистик тоо баримтыг нийтэд нээлттэй болгож, цаазаар авах ялаар шийтгүүлсэн 44 хүний талаарх мэдээллийг Хороонд өгч, цаазаар авах ялыг арай хөнгөн ялаар солих, цаазаар авахуулсан хүний гэр бүлийнхнийг холбогдох мэдээллээр хангах хэрэгтэй. Мөн цаазаар авах ялыг төрийн нууцад хамруулахаа больж, Иргэний ба улс төрийн эрхийн олон улсын пактын 2 дугаар нэмэлт протоколд нэгдэн орох зэрэг цаазаар авах ялыг устгахад чиглэсэн хүч чармайлтаа үргэлжлүүлэхийг Оролцогч улсаас хүсч байна. Цаазаар авах ялтай этгээдтэй олон улсын стандартад нийцүүлэн харьцаж байгаа эсэхэд Оролцогч улс хяналт тавих хэрэгтэй.

### **Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл**

20. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд хүчин чармайлт гаргаж байгаа тэмдэглэхийн сацуу тэдний эсрэг гэр бүлийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэрэг, бэлгийн халдлагын тохиолдол өндөр хэвээр байгаад Хороо зовинож байна. Түүнчлэн гэр бүлийн хүчирхийллийг хууль сахиулах байгууллагын ажилтнуудаас эхлээд ихэнх хүмүүс гэр бүлийн дотоод асуудал мэтээр ойлгодог буюу яллах тохиолдол бага байдаг Хороо харамсаж байна. Нэмж хэлэхэд хүчингийн гэмт хэргийн цөөн тохиолдол бүртгэгдсэн талаар илтгэлд дурдсан ба алслагдсан бүс нутагт хүчингийн гэмт хэргийн дараах эмнэлгийн үзлэг, чадварлаг мэргэжилтнээр хохирогчдыг хамгаалах, нөхөн сэргээх эмчилгээнд хамруулах боломж муутай байдаг зовинож байна. Оролцогч улс гэр бүл дэх хүчин, бэлгийн халдлагын үйлдлийг одоогоор гэмт хэрэгт тооцоогүй байгаад Хороо харамсаж байна. (1,2,4,12,16 зүйл)

Оролцогч улс эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тууштай тэмцэх хэрэгтэй. Ялангуяа хүчин, гэр бүл дэх хүчирхийлэл болон бэлгийн халдлагад анхаарлаа хандуулна уу. Түүнчлэн

гэр бүл дэх хүчин, бэлгийн халдлагыг гэмт хэрэгт тооцох хэрэгтэй. Холбогдох хууль тогтоомжийн талаар мэдлэгтэй, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүхий л хэлбэрийг мэддэг, зөв хандах чадвартай төрийн албан хаагчдыг бэлтгэх шаардлагатай байна. Монгол Улсын өнцөг булан бүрт хүчирхийллийн хохирогч болсон эмэгтэйчүүдэд нөхөн олговор олгох тэднийг хамгаалалт (хамгаалалтад авах шүүхийн шийдвэр, эмнэлгийн шинжилгээ, нөхөн сэргээх эмчилгээ)–д нэн даруй авах шаардлагатай. Хүчирхийлэгч этгээдийг яллах, хэрэв буруутайн тогтоогдвол түүнд таарах шийтгэлийг нь хүлээлгэж байх хэрэгтэй.

### **Хүний наймаа**

21. 2010 оны 10 дугаар сарын 18–ны өдөр БНХАУ–ын засаг захиргааны тусгай бүс болох Макаотай Хүнийг хил дамнуулан худалдаалахтай тэмцэх хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулсан ба энэ чиглэлээр тодорхой ажил хийж байгааг Хороо талархан хүлээж авахын зэрэгцээ хүний наймааны тохиолдол нэмэгдэж байгаад харамсаж байна. Хохирогчдын ихэнх нь ядуу, гудамжны охид, бүсгүйчүүд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид байгаа бөгөөд тэднийг бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгө, хуурамч гэрлэлтийн зорилгоор наймаалж байгаад Хороо зовинож байна. Нэмж хэлэхэд Оролцогч улсад хохирогч, гэрчийг хамгаалах эрх зүйн тогтолцоо сул байна. Оролцогч улсад хүнийг наймаалах гэмт үйлдлийг Эрүүгийн хуулийн 119 дүгээр зүйл буюу “Хүн худалдаалах”–аар зүйлчилж байгаа ч ховор тохиолдож байна. Эрүүгийн хуулийн тус зүйл нь хөнгөн ялтай 124 дүгээр зүйл буюу “Биеэ үнэлүүлэхэд бусдыг татан оролцуулах”–тай харьцуулбал хүнд ял ногдуулсан байдаг. Оролцогч улс илтгэлдээ мөрдөн байцаалт явуулсан нийт хэргийн 85–90 хувийг хангалттай нотлох баримтгүй болон хохирогчийг хууран мэхлэн хил давуулсныг батлах үндэслэл байхгүй гэсэн үндэслэлээр хаасан байна. Түүнчлэн илтгэлд хууль сахиулах байгууллагын ажилтнууд хүн худалдаалах гэмт хэрэгт шууд оролцсон буюу тусалсан талаар дурдсан ч тэднийг шалгаагүй гэжээ. (2,12,13,16 зүйл)

Оролцогч улс нь хүний наймаанаас урьдчилан сэргийлэх, хохирогч, гэрчийг хамгаалах асуудлыг зохицуулсан хууль тогтоомж батлах шаардлагатай ба бүх хохирогчдод нөхөн олговор олгож боломжийн хирээр нөхөн сэргээх эмчилгээнд хамруулах хэрэгтэй. Хууль сахиулах байгууллагын ажилтнууд, мөрдөн байцаагч, прокурор нарыг хүний наймаатай холбоотой хууль тогтоомж, практикийн талаарх сургалтад хамруулна уу. Хүнийг наймаалсан гэмт үйлдлийг Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлээр зүйлчлэх нь зүйтэй. Хүн хүч болон санхүүгийн хангалттай эх үүсвэр бүхий хүний наймаатай тэмцэх арга хэмжээний хэрэгжилтэд мониторинг хийдэг хараат бус механизмыг Оролцогч улс байгуулах шаардлагатай байна. Түүнчлэн хүн наймаалахтай холбоотой аливаа гомдол, мэдээлэл (хууль сахиулах байгууллагын ажилтантай холбоотой мэдээлэл үүнд бас хамаарна)–ийг хөндлөнгийн оролцоогүй, нарийн чанд, үр дүнтэй байдлаар мөрдөн шалгах хэрэгтэй. Оролцогч улс энэ асуудлаар олон улсын, бүс нутгийн болон хоёр талт хамтын ажиллагаагаа өргөжүүлэх шаардлагатай байна.

### **Хөдөлмөрийн мөлжлөг ба хүүхдийн хөдөлмөр**

22. Олон улсын хөдөлмөрийн стандартад нийцээгүй маш аюултай нөхцөлд гар аргаар ашигт малтмал олборлож байгаад Хороо зовинож байна. Түүнчлэн аюултай

нөхцөлд хүүхэд хөдөлмөр эрхэлж байгаа нь Хорооны анхаарлыг татлаа. Илтгэлд дурдсан гудамжны хүүхдүүд болон тэдний байдлыг сайжруулах үүднээс авч буй арга хэмжээ хангалтгүй байгаад мөн харамсаж байна.

Оролцогч улс албадан хөдөлмөрийн бүх хэлбэртэй тэмцэх шаардлагатай байна. Хүүхэд болон гар аргаар ашигт малтмал олборлогчдыг аюултай нөхцөлд хөдөлмөр эрхлэхийг нь зогсоох бүхий л шаардлагатай арга хэмжээ авахыг Оролцогч улсаас хүсч байна. Ийм нөхцөлд хөдөлмөр эрхэлж буй томчуудын ажиллах нөхцлийг олон улсын хөдөлмөрийн стандарт болон Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас баталсан, Оролцогч улсын нэгдэн орсон гэрээ, конвенцид нийцүүлэн сайжруулах шаардлагатай. Хүүхдийн хөдөлмөрийг мөлжигчдийг эрүүгийн хариуцлагад татах замаар хүүхдийн хөдөлмөр эрхлэлттэй тэмцэх, хянах арга хэмжээ авах хэрэгтэй байна. Түүнчлэн Оролцогч улс гудамжны хүүхдийн нөхцлийг сайжруулах талаар арга хэмжээ авна уу.

### **Хүүхдийг шийтгэх**

23. Сургууль, хүүхдийн байгууллага, гэр, ялангуяа хөдөө орон нутагт хүүхдийг шийтгэх явдал их гардагт Хороо зовинож байна. (16 дугаар зүйл)

Оролцогч улс хүүхэд шийтгэх явдлыг таслан зогсооход бүхий л арга хэмжээг яаралтай авах хэрэгтэй байна. Түүнчлэн олон нийтийн боловсрол, мэргэжлийн сургалт зохион байгуулж эерэг, сурагчдыг нийтэд нь хамруулсан, хүчирхийлэлгүй сурган хүмүүжүүлэх хэлбэрийг дэмжих шаардлагатай.

### **Насанд хүрээгүй этгээдийг шүүх ажиллагаа**

24. Насанд хүрээгүй этгээдийг шүүх ажиллагаан дахь хүүхдийн эрх нь Хүүхдийн эрхийн тухай конвенц, түүний зарчмуудад нийцээгүй байна. Түүнчлэн энэ талаар холбогдох хууль тогтоомж хангалтгүй байна. Насанд хүрээгүй этгээдийг шүүхдээ НҮБ-ын “Насанд хүрээгүй этгээдийг шүүхэд баримтлах дүрэм журмын наад захын стандарт”-ыг (1985 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейн баталсан Бээжингийн дүрэм) чанд сахихгүй байгаа ба баривчлах болон цагдан хорих байранд хүүхдийг томчуудаас тусгаарлахгүй байгаад Хороо зовинож байна. (2, 16 дугаар зүйл).

Дотоодын хууль тогтоомжоо олон улсын стандартад нийцүүлэх ажлаа Оролцогч улс дуусгах шаардлагатай байна. Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд насанд хүрээгүй хүнийг аль болох баривчлахгүй байх, баривчлахдаа ямар ч тохиолдолд заавал насанд хүрсэн хүнээс тусгаарлаж байх, НҮБ-ын дээр дурдсан наад захын стандартыг ямар ч тохиолдолд баримталж байх агуулгаар холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах хэрэгтэй. Оролцогч улс насанд хүрээгүй хүний хэргийг шүүх тусгай төрөлжсөн шүүх байгуулж, энэ асуудлаар мэргэшсэн шүүгч, шүүхийн бусад ажилтнуудыг ажиллуулах нь зүйтэй. Шаардлагатай бол Оролцогч улс энэ асуудлаар олон улсын дэмжлэг хүсч болно.

### **Алагчилах ба эмзэг бүлгийн эсрэг хүчирхийлэл**

25. Дараах асуудалд Хороо харамсаж байна. Үүнд:

1/ Алагчилалын эсрэг дотоодын хууль тогтоомж байхгүйгээс гадна үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэрэг, үг хэлээр дайрах үйлдлийг гэмт хэрэгт тооцох эрх зүйн тогтолцоо



байхгүй байна. Лесби, гей, бисексуал, трансжендер хүмүүс нь олон нийтийн болон дотоодын хэмжээнд бэлгийн болон бусад хүчирхийллийн бай болсоор байна. Ингэснээр тэдний талаарх нийгмийн сөрөг хандлага газар авч байна. Эдгээр хүмүүсийг албан ёсоор бүртгэж байгааг Хороо талархан хүлээн авч, олон нийтийн дунд тэдний талаарх мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн кампанит ажил зохион байгуулах шаардлага байгааг ухамсарласанд Хороо талархан тэмдэглэж байна.

- 2/ Орон сууцжуулах эсвэл ажилд авахаас өмнө ХДХВ/ДОХ–той хүмүүсийг алагчилж байна.
- 3/ 2002 онд батлагдсан Иргэний хуульд Монгол Улсын иргэн бус хүн иргэний эрх зүйн харилцаанд иргэний адил эрх эдэлж, үүрэг хүлээхээр заасан нь яс үндсээр нь алагчилсан зохион байгуулалттай хүчирхийлэлд зарим гадаадын иргэдийг өртүүлж болзошгүй байна. (2, 16 дугаар зүйл)

Оролцогч улс алагчилахтай тэмцэх, ялангуяа үзэн ядалтаас үүссэн гэмт хэрэг, үг хэлээр дайрах үйлдлийг зохицуулсан эрх зүйн тогтолцоог бий болгох хэрэгтэй. Ийм төрлийн гэмт хэрэг үйлдэгчдийг шударгаар шүүхэд оролцогч улс тодорхой арга хэмжээ авах шаардлагатай байна. Бэлгийн цөөнх, ХДХВ/ДОХ–той хүмүүс болон зарим гадаадынханыг (эмзэг бүлгийнхэн) хамгаалах нь зүйтэй. Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллээсээ болж халдлагад өртөгсдийн гомдол, мэдээллийг “Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл”–тэй холбоотой асуудалд олон улсын хүний эрхийн эрх зүйг хэрэглэх Жогжакартагийн зарчимд нийцүүлэн түргэн шуурхай, бүрэн гүйцэд, хараат бусаар мөрдөн шалгах бодлого, бодлогын хэрэгжилт, гомдол хянан шийдвэрлэх механизмуудыг Оролцогч улс байгуулах хэрэгтэй байна. Оролцогч улс нь арьс өнгө, яс үндэс болон бусад хэлбэрээр алагчлах явдлыг дэмждэг, өдөөн хатгадаг зохион байгуулалттай бүлэг, байгууллагатай тэмцэх хууль тогтоомж батлах хэрэгтэй байна.

### **Сэтгэцийн өвчтэй хүмүүс**

26. Сэтгэцийн өвчтэй буюу оюун ухааны бэрхшээлтэй хүмүүсийг эмнэлэгт хэвтүүлж эмчлэх явцад мониторинг хийх, хараа хяналт тавихтай холбоотой эрх зүйн хамгаалалтын өнөөгийн байдлын талаар мэдээлэл муу өгсөнд Хороо харамсаж байна. Түүнчлэн ийм хүмүүсийг гол төлөв эмнэлэгт хэвтүүлэх хандлагатай байдаг болон цөөн тооны эмчилгээний арга хэрэглэдэгт Хороо зовинохоос гадна тусгай мэргэшсэн боловсон хүчний тоо хангалтгүй байгаа нь анхаарал татлаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн (сэтгэцийн өвчтэй ч мөн адил) эрхийг баталгаажуулсан эрх зүйн хэм хэмжээг нэн түрүүнд батлах шаардлагатай байна. Эмнэлгийн үйл ажиллагаанд мониторинг хийх, хараа хяналт тавих механизмыг нэн яаралтай бий болгоно уу. Мөн сэтгэцийн өвчтэй болон бусад хөгжлийн бэрхшээлтэй хүнийг эмчлэх, асрах шинэ шинэ аргуудыг амьдралд нэвтрүүлж, сэтгэлзүй болон сэтгэлзүйн эмгэг судлалаар мэргэшсэн боловсон хүчний тоог нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

### **Мэдээлэл цуглуулах нь**

27. Хууль хяналтын байгууллага, аюулгүй байдал, цэрэг арми, шоронгоос эрүүдэн шүүх, зүй бусаар харьцсан үйлдлийн талаар хэдэн өргөдөл гомдол хүлээн авсан,

хэдийг нь мөрдөн байцаасан, хэдэнд нь яллах дүгнэлт үйлдсэн, хэдэн буруутанг хорьж шийтгэсэн талаар дэлгэрэнгүй, тодорхой тоо баримт аваагүйд Хороо харамсаж байна. Түүнчлэн цаазлуулах ялтай хоригдол, цагаач ажилчидтай зүй бусаар харьцсан тохиолдол, хүний наймаа, гэр бүл дэх болон бэлгийн хүчирхийллийн талаар мэдээ баримт хангалтгүй байлаа.

Оролцогч улс үндэсний хэмжээнд Конвенцийн хэрэгжилтийн байдалд мониторинг хийхдээ дараах статистик тоо баримт цуглуулах шаардлагатай. Үүнд:

- Эрүүдэн шүүх, зүй бус харьцсан үйлдлийн талаар ирсэн өргөдөл гомдлын тоо;
- Дээрх үйлдэлд холбогдуулж шалгасан албан хаагчдын тоо, тэднээс хэдийг нь ялласан, хэдийг нь хорьж шийтгэсэн талаарх баримт;
- Цагаачлан ирсэн ажилчидтай зүй бус харьцсан хэдэн тохиолдол гарсан;
- Цаазаар авах ялтай хүний тоо;
- Хүний наймааны хэдэн тохиолдол байгаа;
- Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл;

Эдгээр статистик тоо баримтыг гаргахдаа нас, хүйс, угсаа гарал, гэмт хэргийн төрлөөр нь тус тус ангилахаас гадна нөхөн олговор олгосон эсэх, нөхөн сэргээх эмчилгээнд хамруулсан эсэх зэргээр нь тодорхой ялгах хэрэгтэй.

28. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн Нэмэлт протоколд нэгдэн орох асуудлыг Оролцогч улс түргэн шийдвэрлэхийг санал болгож байна.

29. Конвенцийн 21, 22 дугаар зүйлд заасны дагуу Оролцогч улс мэдэгдэл хийхийг зөвлөж байна.

30. НҮБ-ын хүний эрхийн үндсэн гэрээ, конвенцид нэгдэж орохыг Оролцогч улсад уриалж байна. Тухайлбал, Цагаач ажилчид, тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенц, Бүх хүнийг хүч хэрэглэн алга болгохоос хамгаалах тухай олон улсын конвенц зэрэг болно.

31. Хороонд барьсан ээлжит илтгэл, санал зөвлөмжийг орчуулж албан ёсны цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон төрийн бус байгууллагад тараахыг хүсч байна.

32. Тус зөвлөмжийн 9, 11, 16, 19 дахь хэсэгт заасан зөвлөмжийн хариу мэдээллийг нэг жилийн дотор ирүүлэхийг Оролцогч улсаас хүсье.

33. Дараагийн ээлжит илтгэл нь 40 хуудаснаас илүүгүй, Хорооноос баталсан удирдамжийн дагуу боловсруулагдсан байхад Оролцогч улс анхаарна уу. Түүнчлэн хүний эрхийн олон гэрээ, конвенциудаар байгуулагдсан хороонуудын хамтарсан хурлаас баталсан олон улсын хүний эрхийн гэрээнүүдийн хэрэгжилтийн талаарх илтгэл боловсруулахад баримтлах удирдамж (HRI/GEN.2/Rev.6) дахь “Нийтлэг гол баримт бичиг”-д заасан баримт бичгүүдийг Хороонд ирүүлэхийг Оролцогч улсаас хүсч байна. Эдгээр баримт бичгүүдийг 80 хуудаснаас хэтрүүлэхгүй байхыг анхаарна уу. Илтгэл, баримт бичгүүдийг хамтад нь Хороонд ирүүлснээр олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ Оролцогч улс биелүүллээ гэж үзэх юм.

34. 2014 оны 11 дүгээр сарын 19-ны өдрөөс өмнө Оролцогч улс ээлжит 2 дахь илтгэлээ Хороонд ирүүлнэ үү.

### **7.3 ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР БУЮУ ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХОЁРДУГААР ИЛТГЭЛ**

#### **I хэсэг: ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

1. Монгол Улсын улс төрийн байдал, эрх зүйн тогтолцооны ерөнхий тодорхой мэдээлэл нь НҮБ–д хүргүүлдэг хавсралт цөм мэдээлэлд багтсан тул илтгэлтэй холбоотой товч хэсгийг энэ хэсэгт багтаав.

2. Тайланд тусгасан мэдээлэл нь 2010–2014 оныг багтаана.

3. Монгол Улсын Үндсэн хуулиар иргэний эрхийг баталгаажуулсан. 2000 оны 12 дугаар сарын 7–ны өдөр Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль батлагдсанаар Парисын зарчмуудад нийцсэн Хүний эрхийн Үндэсний Байгууллага байгуулагдан, Монгол Улсын Үндсэн Хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэнд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхиүлэн дэмжих чиглэлээр ажиллаж байна.

4. Монгол Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолоор “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”–ийг баталсан ба баримт бичиг нь төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангах баталгаа – механизмыг бүрдүүлэх, уул эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг тууштай, үр нөлөөтэй хэрэгжүүлэх үйлсэд засаг төрийн байгууллага, албан тушаалтны санаачлага, хариуцлагыг дээшлүүлэн, иргэний нийгэм, юуны өмнө нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн бус байгууллага, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хувийн хэвшлийн оролцоог өргөтгөн, үр нөлөөг нь сайжруулах, иргэдийн санаачлагыг өрнүүлэх чиглэл, арга замыг тодорхойлно. Хөтөлбөрийг Засгийн газар 2003 оноос дөрөв, дөрвөн жилээр тодотгосон төлөвлөгөөтэйгээр эрхлэн хэрэгжүүлж байна.

5. Монгол Улс “Эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцахын эсрэг конвенц”–ийг 2002 онд соёрхон батлан “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг НҮБ–ын конвенцийн Нэмэлт Протокол”–д НҮБ–ын Ерөнхий Ассамблейн 68 дугаар чуулганы үеэр (2013 оны 9 дүгээр сарын 24–ний өдөр) гарын үсэг зурсан.

6. Монгол Улс анхны тайлангаа НҮБ–ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд 2010 онд хүргүүлж, 2010 оны 11 дүгээр сарын 1–19–ний өдрийн 49 дүгээр хуралдаанаар гаргасан зөвлөмжийг хүлээн авсан.

7. Монгол Улсын Ерөнхийлөгч Эрүүгийн хуульд заасан хэмжээ хязгаарын хүрээнд ял эдэлж байгаа ялганд уучлал үзүүлэх бүрэн эрхийн дагуу 2010 онд цаазаар авах ялаас түдгэлзэж, энэ хугацаанд нэг ч хүн цаазаар авахуулаагүй байна.

8. Тайлангийн хугацаанд Монгол Улс хүний эрхийг хангах чиглэлд эрх зүйн шинэтгэлийн хүрээнд болон НҮБ–ын хүний эрхий зөвлөлийн гишүүн орнуудаас өгсөн зөвлөмжийг үндэслэн дараах олон улсын олон талт гэрээ хэлэлцээрт нэгдэн орж,

хэрэгжилтийг хангахаар дотоодын арга хэмжээг авсан.

- 1) “Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенц”-ийг 2014 оны 10 дугаар сарын 09-ний өдөр соёрхон баталсан.
  - 2) “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протокол”-ыг 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдөр соёрхон баталсан.
  - 3) “Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протокол”-ыг 2010 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр соёрхон баталсан.
  - 4) “Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын Цаазаар авах ялыг халах тухай II протокол”-ыг 2012 оны 1 дүгээр сарын 5-нд соёрхон баталсан.
9. Улсын Их Хурлын чуулганаар дараах хуулиудыг батлуулсан. Үүнд:
- 1) Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хууль 2013 он,
  - 2) Цагдаагийн албаны тухай хууль 2013 он,
  - 3) Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль 2013 он,
  - 4) Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль 2013 он,
  - 5) Тахарын албаны тухай хууль 2013 он.

10. Монгол улсад 20373 гэмт хэрэг бүртгэгдэж, 7513 хүн 2009 онд шүүхээр шийтгүүлж ял авсан байдаг бол 25362 гэмт хэрэг 2013 онд бүртгэгдэж, 8067 хүн шүүхээр ял шийтгүүлсэн байна. 2013 онд шүүхээр ял шийтгүүлсэн нийт хүний 696 нь эмэгтэй, 504 нь 18 хүртэл насны хүүхэд байв. Мөн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэргийн 46,8% нь өмчлөх эрхийн гэмт хэрэг, 34% нь хүний амь, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг байв.

11. Улсын Дээд Шүүхийн 2013 оны эхний хагас жилийн дүн статистикаас харахад 2013 оны эхний жилд 4087 хүн ял шийтгүүлснээс 3086 хорих ялаар шийтгүүлсэн бөгөөд үүний 1261 нь хорих ялыг биеэр эдлүүлэх, 1563 нь тэнссэн, 243 нь хорих ялыг хойшлуулсан, 188 насанд хүрсэн ба насанд хүрээгүй, 9 хүнд өршөөл үзүүлсэн байна. Мөн хорихоос өөр төрлийн ялаар буюу торгох, албадан ажил хийлгэх, баривчлах зэрэг ялын хэлбэрээр 933 хүн шийтгүүлсэн байна.

12. Хууль зүйн яамнаас хууль сахиулах (ЦЕГ, Тахарын ерөнхий газар, ИХШХЕГ зэрэг) байгууллагуудад дотоод хяналтын тогтолцоог бий болгон, бэхжүүлж ажилтан алба хаагчдын зөрчил, үйл ажиллагаанд хяналт тавьж, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллаж байна. Мөн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлж ажиллаж байна.

13. Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний эрх ашиг, төрийн тусгаар тогтнол, аюулгүй байдал, хүн төрөлхтөний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор гэмт хэрэг түүнд хүлээлгэх ял, албадлагын арга хэмжээг “Гэмт хэргийн тухай хууль”-аар, хууль тогтоомж, журмаар тогтоосон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг зөрчигдөхөөс хамгаалах зорилгоор зөрчил, түүнд хүлээлгэх шийтгэлийн төрөл хэмжээг “Зөрчлийн тухай хууль”-аар зохицуулахаар хуулийн төсөл боловсруулаад байна.

14. “Эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцахын эсрэг конвенц”-ийн 19–р зүйлд заасны дагуу Монгол Улс анхны тайлангаа хүргүүлсэнээс хойш шинээр авсан арга хэмжээний талаарх хоёрдугаар тайлангаа боловсруулан хүргүүлж байна.

15. Энэхүү илтгэлийг Хууль зүйн яам Улсын Ерөнхий прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Улсын дээд шүүх, Цагдаагийн ерөнхий газар, Хүний эрхийн үндэсний комисс, Авлигатай тэмцэх газартай хамтран бэлтгэж, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулан, саналыг тусгасан болно.

## **II хэсэг: ХЭРЭГЖИЛТ ЗҮЙЛ ТУС БҮРЭЭР**

### **1 дүгээр зүйл. Конвенцийн хэрэгжилт, дотоодын хууль тогтоомж**

*Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй.*

(Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалт)

16. Түүнчлэн Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд уг хуулийн зорилтыг тодорхойлохдоо “...аливаа гэмт хэргийг шуурхай бүрэн илрүүлж, гэмт этгээдийг олж тогтоох, гэмт хэрэг үйлдсэн этгээд нэг бүрт зохих ялыг шударгаар оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн буруутайд тооцохгүй байх явдлыг хангахад оршино” гэж зааж Монгол Улсын Эрүүгийн хуулиар хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжлохыг хориглосон заалтыг хуульчилсан бөгөөд сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг өгөхийг шаардах, түүнтэй хүнлэг бус, хэрцгий харьцах, нэр төрийг нь гутаан доромжлохыг хориглосон бөгөөд дээрх үйлдлийг гаргасан этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан билээ.

17. Монгол Улс эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжлохыг хориглож, хохирогчийг хамгаалахтай холбоотой дараах хууль тогтоомж үйлчилж байна. Үүнд.

- 1) Эрүүгийн Хууль;
- 2) Эрүүгийн байцаан шийтгэх хууль;
- 3) Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай;
- 4) Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль;
- 5) Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль;
- 6) Төлбөрийн чадваргүй яллагдагчид эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хууль;
- 7) Авлигын эсрэг хууль;
- 8) Иргэний хууль;
- 9) Иргэний хэрэг хянан шийдвэрлэх хууль;
- 10) Цагдаагийн албаны тухай;
- 11) Тахарын албаны тухай.

18. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийг үндэсний хууль тогтоомжид тусгаж хэрэгжүүлэхийн зэрэгцээ зөвхөн хуульд заасан арга, хэрэгслээр бусдын эрх, эрх чөлөөг хязгаарлах, хүний эрхэнд халдах эрх бүхий субъектүүд эрүү шүүлтийн аливаа хэлбэрээр бусдын эрхэнд халдсан тохиолдолд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын чангатгаж, урьд Хороонд хүргүүлсэн тайлангаас хойш Эрүүгийн хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

19. Тус Эрүүгийн хуулийн 248 дугаар зүйлд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч шунахай болон хувийн сэдэлтээр илт гэм буруугүй хүнийг сэжигтнээр тооцох, яллагдагчаар татах, ял шийтгэсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан бөгөөд бусдыг хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогдуулсан, энэ хэргийн улмаас хохирогчид их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа эрлэх эрхийг гурван жил хүртэл хасах буюу хасахгүйгээр таваас дээш 10 жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэхээр тусгажээ.

20. Мөн хуулийн 249 дүгээр зүйлд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч шунахай болон хувийн бусад сэдэлтээр илт хууль бусаар хүнийг баривчилсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа эрхлэх эрхийг гурван жил хүртэл хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан байна. Энэ нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 1 дүгээр зүйлд заасан “эрүү шүүлт гэж ....ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийн бие махбодь, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг” хэлнэ гэж тодорхойлсны дагуу дээр дурьдсан субъектүүдийн хууль бус аргаар хүний эрхэнд халдах аливаа үйлдэл нь эрүү шүүлтийн нэг төрөлд хамаарагдахаар үндэсний хууль тогтоомжид тусгалаа олсон байна.

**251 дүгээр зүйл. Эрүү шүүлт тулгах**

*/Энэ зүйлийн гарчигт 2008 оны 2 дугаар сарын 01–ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

251.1.Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, тарчилган зовоох, тохуурхан даажигнах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэж мэдүүлэг өгөхийг албадан эрүү шүүлт тулгасан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасч таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

*/Энэ хэсэгт 2008 оны 2 дугаар сарын 01–ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

251.2.Энэ хэргийн улмаас хүний бие махбодид хүндэвтэр, хүнд гэмтэл, их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасч таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ

*/Энэ хэсэгт 2008 оны 2 дугаар сарын 01–ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

251.3.Энэ хэргийн улмаас хохирогч нас барсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

*/Энэ хэсгийг 2008 оны 2 дугаар сарын 01–ний өдрийн хуулиар нэмсэн/*

21. Манай улс нь НҮБ–ын гишүүн улсын хувьд хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах үндэслэл, журмыг дотоодын хууль тогтоомжийн хүрээнд хуульчлан тогтоохдоо Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон Улс төрийн эрхийн олон улсын пакт, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцид заасан суурь зарчимд нийцүүлэх үүрэгтэй. Энэ үүргийн хүрээнд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4–т “Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн” гээд 3.3.1.5–т “Хүний эрх, эрх чөлөөг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлж, энэ чиглэлд институц хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулна” гэжээ.

22. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2012–2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт шүүхээс гадуур хүний эрхийг хязгаарлаж, эрүүгийн хэргийг байцаан шалгадаг тогтолцоог халж, шүүхийн хяналтын дор эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тогтолцооны эрх зүйн үндсийг тогтоох арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгасан байна.

23. Хууль сахиулагчид хүний эрхийг хязгаарлах тэр дундаа хүч, албадлага хэрэглэх онцгой эрхтэй байдаг. Олон Улсын хүний эрхийн стандартад хууль сахиулагч хүчийг гарцаагүй нөхцөлд эцсийн арга болгон тохирсон хэм хэмжээнд бүрэн хяналтын дор хэрэглэх<sup>1</sup> зарчмыг заасан байдаг. Харин манай улсын хувьд хууль сахиулагчийн хүч, албадлага хэрэглэх эрх хэмжээг хэт ерөнхий байдлаар хуульчилсан төдийгүй үндэслэлийг салангид байдлаар өөр өөр хуулиар<sup>2</sup>, хэрэглэх журмыг Улсын ерөнхий прокурор болон тухайн байгууллагын дарга хамтран баталсан тус тусын журмаар<sup>3</sup> зохицуулж байна.

## **2 дугаар зүйл. Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх актуудад авсан арга хэмжээ**

24. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц нь эрх чөлөө хязгаарлах аливаа газар объект төдийгүй нас, эрүүл мэнд, бие бялдрын хөгжлөөс хамааран бусдын эрхшээлд байгаа хүмүүсийн халамж, асрамжийн газар гэх мэт төрийн байгууллага, зарим тохиолдолд төрийн чиг үүргийг хэрэгжүүлж буй иргэний нийгмийн болон хувийн хэвшлийн байгууллагад ч адилхан хамаарч үйлчлэх зорилготой.

---

<sup>1</sup> Хууль сахиулагчийн зан үйлийн дүрэм – Ерөнхий Ассамблейн 1979 оны 12 дугаар сарын 17–ны 34/169А тоот тогтоол.

Нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан галт зэвсэг болон хүч хэрэглэх үндсэн зарчим. НҮБ–ын 8–р Их хурал. 1990–8–27.

<sup>2</sup> Хууль сахиулагчийн “Галт зэвсэг” хэрэглэх эрх хэмжээ, үндэслэлийг 10 орчим хуульд, “Тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх” эрх хэмжээ, үндэслэлийг мөн 10 орчим хуулиар олгосон байна. Ажлын хэсгээс хийсэн судалгаа. 2012 он.

<sup>3</sup> Тухайн журмыг Улсын ерөнхий прокурор болон тухайн байгууллагын дарга хамтран, эсхүл тухайн байгууллагын дарга нь Төрийн захиргааны төв байгууллагын саналыг харгалзан, Улсын ерөнхий прокурор зөвшилцөн батлахаар хуульчилсан байна. Ажлын хэсгээс хийсэн судалгаа. 2012 он.

25. Дээрх зорилго нь Монгол Улсын салбар хууль тогтоомжид тусгагдсан бөгөөд тухайлбал Прокурорын байгууллагын тухай хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар прокурор ял эдлүүлэх дараах ажиллагаанд хяналт тавина гэж тодорхойлсон. Үүнд:

14.1.1. баривчлах, хорих болон бусад төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэх;

14.1.2. баривчлах болон хорих ял эдлүүлэх ажиллагаа хуулиар тогтоосон нөхцөл, дэглэмд нийцэж байгаа эсэх;

14.1.3. эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэглэж байгаа эсэх;

14.1.4. ял эдэлж байгаа этгээдийн хууль ёсны эрхийг хангаж байгаа эсэх.

14.2. Прокурор энэ хуулийн 14.1–д заасан ажиллагаанд хяналт тавихдаа дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.2.1. шийтгэх тогтоолыг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан хугацаанд ирүүлэхийг шүүхээс шаардах;

14.2.2. баривчлах, хорих ял эдлүүлэх газарт ямар ч цагт саадгүй нэвтрэх, ял эдлүүлэх үндэслэл болсон тогтоол, шийдвэр, баримт бичигтэй танилцах, ялантай биечлэн уулзах, шаардлагатай бол тайлбар гаргуулах, тодорхойлолт авах;

14.2.3. ял эдлүүлэлтийн байдлыг шалгах, танилцах, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

14.2.4. шүүхийн шийдвэр гүйцэтгэх талаар хуульд тусгайлан заасан тохиолдолд дүгнэлт гаргах, шинжээч томилох;

14.2.5. баривчлах, хорих ял эдлүүлж байгаа нөхцөл, дэглэмийг шалгах, хууль бусаар хоригдож байгаа хүнийг нэн даруй суллах;

14.2.6. тогтоол биелүүлэхийг хойшлуулах, торгох, албадан ажил хийлгэх ялыг өөр ялаар солих, өвчний учир ял эдлүүлэхээс чөлөөлөх, хугацаанаас өмнө ялаас чөлөөлөх, эдлээгүй үлдсэн ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих, гянданд эдлүүлэх ялыг хорих ангид эдлүүлэхээр солих, хорих ангид эдлэх ялыг гянданд хорихоор солих асуудлыг шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцож дүгнэлт гаргах.

26. Дээрх бүрэн эрхтэй холбогдуулан Прокурорын байгууллага цагдан хоригдсон, ял эдэлж байгаа хүмүүсийн хоригдож буй нөхцөлийг шалгах, тэдгээрээс ирүүлсэн гомдол хүсэлтийг шалгаж зөрчигдсөн эрхийг сэргээх, хоригдож буй нөхцлийг сайжруулах талаар холбогдох газар шаардлага, санал хүргүүлэн, хууль зөрчсөн албан тушаалтанд хариуцлага тооцуулж байна.

27. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68, 69, 70, 114 дүгээр зүйлүүдийг нэг мөр хэрэглэх, хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын шатанд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдаж буй хүний эрх зөрчигдөхгүй, сэжигтэн, яллагдагч, тэдгээрийн ар гэр, өмгөөлөгчид цагдан хоригдсон үндэслэлийг шуурхай танилцуулах, сэжигтэн, яллагдагч баривчлагдсан, цагдан хоригдсон үндэслэлийг эс зөвшөөрч шүүгчид өөрийн биеэр тайлбар өгөх боломжийг хангах зорилгоор шүүх, прокурорын байгууллага эрх хэмжээний хүрээнд хуульд нийцүүлэн тодорхой журам, заавар гаргасан. Тухайлбал: 2008 оны 01 дүгээр сарын 30–ны өдөр Улсын Дээд Шүүхийн Ерөнхий Шүүгч, Улсын Ерөнхий Прокурор хамтран “Цагдан



хорихтой холбогдсон зарим ажиллагааг зохицуулах тухай журам”, Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2011 оны 12 дугаар сарын 11–ний өдрийн 214 тоот, 2013 оны 02 дугаар сарын 05–ны өдрийн А/14 тоот тушаалаар “Ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын заавар”-ыг батлан мөрдүүлж байна. “Цагдан хорихтой холбогдсон зарим ажиллагааг зохицуулах тухай журмаар” цагдан хоригдох таслан сэргийлэх арга хэмжээ авагдаж буй сэжигтэн, яллагдагчийн эрхийг хангах, цагдан хорих санал гаргах эрх бүхий субъектийн шуурхай байх явдлын хангах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хүнд, түүний ар гэр, өмгөөлөгчид энэ талаар 24 цагийн дотор мэдэгдэж байх, шаардлагатай бол шүүгч цагдан хоригдож буй хүнтэй биечлэн уулзах зэрэг харилцааг зохицуулж байна.

28. “Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих прокурорын хяналтын заавар”-аар ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналт хариуцсан прокурор шүүхээс оногдуулсан шийтгэх тогтоолын биелэлтийг хянах, танилцах, тогтоолын хэрэгжилтийг шалгах аас гадна мөн хорих ангийн харуул хамгаалалт, ялтны ял эдэлж буй ахуй, нөхцөл стандарт хангасан эсэх, өрөөнүүдийн чийглэг, дулааны хэмжээг шалгаж тодорхойлох, баривчлах болон хорих байрны дэглэм, харуул хамгаалалт, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах боломж, нөхцөл, ялтанг журамд заасан хэмжээ, илчлэгтэй хоолоор хангаж байгаа эсэх, ялтны эрхийг хангаж байгаа байдлыг улирал бүр шалгаж, дээд шатны прокурор ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналт хариуцсан прокурорын ажилтай тогтмол танилцан жилд 2–оос доошгүй удаа ажлын үр дүнг зөвлөлийн хурлаар хэлэцүүлж байх тухай зохицуулсан. Мөн дээрх аргачлалаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчид нь хорих болон хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн ялтан, цагдан хоригдож байгаа сэжигтэн, яллагдагч нартай зүй бус харьцсан, эрүүгийн хэрэг үүсгэн шалгагдаж байгаа талаар Улсын Ерөнхий Прокурорт нэн даруй танилцуулахыг үүрэг болгосон.

29. Баривчлагдсан, цагдан хоригдсон хүмүүсийн амаар болон бичгээр гаргасан хүсэлт, гомдлыг хүлээн авч, шалгах, шийдвэрлэх харилцааг зохицуулж өгсөн.

**3 дугаар зүйл. Эрүүдэн шүүгдэж буй гэмт этгээдийг зөвшөөрөлгүйгээр  
эх оронд нь буцааж хариулах, шилжүүлэх**

30. Монгол Улсын эрх зүйн салбар дахь хамтын ажиллагааны гол зорилгын нэг нь өөрийн улсын иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх болон ашиг сонирхлыг хилийн чанадад хангах, хамгаалах асуудал байдаг байна.

31. Монгол Улсын гадаад харилцаа эрчимтэй хөгжиж эхэлсэн 1960–аад оноос эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх баримт бичгүүдийг бусад улс орнуудтай байгуулж өөрийн болон гадаад иргэдийн эрх ашгийг хамгаалж эхэлсэн. Хамгийн анхны гэрээг 1968 онд Бүгд Найрамдах Унгар Улстай 1968 онд “Иргэн, гэр бүл болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ” байгуулсан бол хамгийн сүүлд 2011 онд Бүгд Найрамдах Хятад Ард Улстай Ялтан шилжүүлэх гэрээг байгуулаад байна.

32. Нийт 19 улстай 26 гэрээг Иргэний хэргээр эрх зүйн туслалцаа үзүүлэх, Эрүүгийн хэргээр эрх зүйн туслалцаа үзүүлэх, Гэмт этгээд шилжүүлэх, Ялтан шилжүүлэх асуудлаар байгуулсан. /хавсралт 1, 2,3/

33. Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу Монгол Улсын иргэнийг харьяатаас хасах, эх орноосоо хөөх, өөр улсад шилжүүлэн өгөхийг хориглох бөгөөд Эрүүгийн хуулийн 15 дугаар зүйлд: 1) Монгол Улсын иргэнийг эрүүгийн хэрэгт мөрдүүлэх буюу эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр гадаад улсад шилжүүлж өгөхгүй; 2) Монгол Улсын хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнийг эрүүгийн хариуцлага хүлээлгэх буюу ял эдлүүлэхээр Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу гадаад улсад шилжүүлж болно гэж заасан байна.

34. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийг 2010 оны 7 дугаар сарын 08-ны өдөр баталж, 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдөр 2013 онд нэмэлт өөрчлөлт орсон. Энэхүү нэмэлт өөрчлөлтөөр Гадаадын иргэн харьяатын асуудал эрхлэх газар нь Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар нэртэйгээр өөрчлөгдөж, үйл ажиллагаа нь 2014 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Хилийн боомтын тухай хуулийн дагуу өргөжсөн.

35. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлд гадаадын иргэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал дараах үндэслэлээр Монгол Улсаас албадан гаргана:

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр бус буюу хуурамч баримт бичгээр нэвтэрсэн нь нотлогдсон;
2. оршин суух зөвшөөрлийн хугацаа нь дууссан боловч Монгол Улсаас гарч явахаас зайлсхийсэн;
3. түр ирэгч нь виз, бүртгэлийн журмыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчиж энэ хуульд заасан хариуцлага хүлээсэн;
4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хориглосон үйл ажиллагаа явуулсан;
5. Сэтгэцийн өвчтэй болохыг нь эрүүл мэндийн байгууллага тогтоосон; /Энэ заалтад 2012 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/
6. хуурамч баримт бичиг ашиглаж виз, оршин суух зөвшөөрөл авсан, эсхүл виз, оршин суух зөвшөөрлийг засварласан буюу хуурамчаар үйлдсэн;
7. эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хөдөлмөр эрхэлсэн, ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан;
8. энэ хуулийн 35.1-д заасны дагуу Монгол Улсаас сайн дураараа гарах сануулгыг биелүүлээгүй;
9. нийгмийн хэв журмыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчиж захиргааны арга хэмжээ авагдсан гадаадын иргэний талаар цагдаагийн байгууллагаас үндэслэл бүхий санал ирүүлсэн;
10. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын эсрэг үйл ажиллагаа явуулж болзошгүй этгээд гэж холбогдох байгууллагаас үзсэн;
11. шүүхээр ял шийтгүүлсэн гадаадын иргэн ялаа эдэлж дууссан буюу ялаас чөлөөлөгдсөн, эсхүл тухайн гадаадын иргэнийг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу харьяалах улсад нь шилжүүлэхээр болсон;
12. түр ирэгч визийн хугацааг хэтрүүлсэн.

36. Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах тухай шийдвэрийг гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга гаргана.

37. Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Монгол Улсаас албадан гаргаж байгаа гадаадын иргэний фото зураг, гарын хурууны хээг авч мэдээллийн сан бүрдүүлнэ. Албадан гаргах тухай шийдвэрийг иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хил хамгаалах болон цагдаагийн байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

38. Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь албадан гаргаж байгаа гадаадын иргэний паспорт, баримт бичигт Монгол Улсад орохыг хориглосон хугацааг заасан тэмдэглэл хийнэ. Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах зардлыг гадаадын иргэнээс өөрөөс нь, эсхүл уригчаас гаргуулах ба хэрэв төлбөрийн чадваргүй бол уг зардлыг Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гаргана.

39. Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах нь улс хооронд ялтан шилжүүлэх асуудалд үл хамаарна. Албадан гаргаж байгаа гадаадын иргэнийг харьяалах улсад нь шилжүүлнэ.

40. Хэрэв шууд шилжүүлэх боломжгүй бол урьд нь оршин сууж байсан буюу төрсөн улсад нь; Монгол Улсад нэвтрэн орж ирэхдээ хамгийн сүүлд дамжин орж ирсэн улсад нь; визийг нь авсан улсын аль нэгэнд шилжүүлж болно.

41. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 46 дугаар бүлэгт гадаад улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн буюу шийтгэгдсэн гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнийг шилжүүлэн өгөх, 47 дугаар бүлэгт Монгол Улсын шүүхэр хорих ял шийтгүүлсэн этгээдийг харьяат улсад нь шилжүүлэн өгөх талаар зохицуулсан бөгөөд эдгээр асуудлыг олон улсын гэрээ, хэлэлцээрт заасны дагуу шийдвэрлэнэ гэсэн байна.

42. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 46, 47 дугаар зүйлүүдэд шилжүүлэн өгөхөөс татгалзах үндэслэлүүдийг тусгасан боловч “эрүүдэн шүүх аюул тулгарна” гэж үзэх хангалттай үндэслэл байх тохиолдлыг тусгайлан заагаагүй боловч Монгол Улсын нэгдэн орсон гэрээ хэлэлцээр, байгуулсан хоёр талт гэрээ, хэлэлцээрүүдэд татгалзах үндэслэл болох тохиолдолуудыг тусгасан байдаг.

43. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний зүйлд эрх зүйн хамгаалалтын асуудал багтах бөгөөд мөн зарим хөнгөлөлтийг агуулж болдог. 1954 оны иргэний процессын асуудлын тухай Гаагийн конвенцийн 24 дүгээр зүйлийн дагуу харилцан хэлэлцэгч улсууд иргэний бүртгэлийн талаарх мэдээллийг үнэ төлбөргүй авах эрхтэй. Хэлэлцэн тохирогч улсууд үндэсний дэглэмийг харилцан тэгш олгох зарчим дээр үндэслэн тэгш олгоно.

#### **4–р зүйл “Улс бүр эрүүгийн байцаан шийтгэх хуулиндаа эрүүдэн шүүх асуудлын талаар тодорхой хуульчилж өгөх ёстой”**

44. 2008 оны 02 дугаар сарын 01–ний өдөр Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 251 дүгээр зүйлд заасан “Мэдүүлэг өгөхийг албадах” гэмт хэргийг “Эрүү шүүлт тулгах” гэж өөрчлөн хэрэг бүртгэгч,

мөрдөн байцаагчийн бусдаас мэдүүлэг өгөхийг албадсан аливаа үйлдлийг эрүү шүүлт тулгасан гэмт хэрэгт тооцохоор болж бусдад эрүү шүүлт тулгасан хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид хүлээлгэх ял шийтгэлийг чангатгаж тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг заавал хасч байхаар тусгасан. Энэ нь Монгол Улсад Хорооноос ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх үүднээс хийсэн томоохон алхмын нэг үзэж байна.

45. Мөн хуулийн 3 дахь зүйлд энэ хэргийн улмаас хохирогч нас барсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр зааж онц хүнд гэмт хэргийн ангилалд оруулж өгсөн нь эрүү шүүлтийн аливаа хэлбэрийг гэмт хэрэгт тооцож энэ нь онц аюултай гэмт хэрэг гэдгийг харгалзан үзнэ гэсэн конвенцийн заалттай нийцэж байна.

46. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар “эрүү шүүлт тулгах” гэмт хэрэг үйлдэх субъектийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч гэж хязгаарласанд хүний эрхийн байгууллагаас шүүмжилж байгаа бөгөөд шинээр боловсруулж Улсын Их Хуралд өргөн барьсан “Гэмт хэргийн тухай хууль”-ийн 21 дүгээр бүлгийн 14 дүгээр зүйлийг “Эрүүдэн шүүх гэж өөрчлөн уг зүйлд “ Нийтийн албан тушаалтан өөрөө, эсхүл бусдыг хатгаж, эсхүл бусдад зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар зөвшөөрч буйгаа илэрхийлж хүнээс тайлбар, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял, шийтгэл оногдуулах зорилгоор, эсхүл ял, шийтгэл эдэлж байгаатай нь холбогдуулан өөрт нь эсхүл бусад хүний бие махбод, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоосон бол дөрвөн мянга зургаан зуун далан тооцооны нэгжээс хорин дөрвөн мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” хэмээн уг гэмт хэргийн бүрэлдхүүн, хамрагдах субъект зэргийг илүү өргөн хүрээтэй тодорхойлсон нь конвенцийн агуулгад илүү нийцэж байна.

47. Мөн “Гэмт хэргийн тухай хууль”-ийн төслийн 13 дугаар бүлэгт хууль сахиулагчдын зүгээс гэмт хэргийг илрүүлэх, шалгах, нотлохдоо аливаа хууль бус хэлбэрээр бусдын эрхэнд халдах, айлган сүрдүүлэх аливаа, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлах, хорих үйлдлүүдийг тус бүрд нь гэмт хэрэгт тооцож, гэмт хэргийн бүрэлдхүүнийг илүү өргөн хүрээнд тодорхойлон уг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, оногдуулах хорих ялын хэмжээг 1–5 жил байхаар зохицуулсан конвенцийн агуулгад нийцэж байна.

**5 дугаар зүйл. 4–р зүйлд дурдагдсан гэмт хэрэг,  
зөрчлүүдийг шийдвэрлэх хууль тогтоомж**

48. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2007 оны 8 дугаар сарын 9–ний өдрийн хуулиар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 59 дүгээр зүйлд “Хэрэг бүртгэгч мөрдөн байцаагч нь сэжигтнийг баривчлах тухай тогтоол үйлдэж прокурорт танилцуулах бөгөөд прокурор нь шүүхэд танилцуулж шийдвэрлүүлнэ, “хойшлуулшгүй тохиолдолд” хэрэг бүртгэгч мөрдөн байцаагч сэжигтнийг шууд баривчилж 24 цагийн дотор тогтоолыг прокурорт болон шүүхэд хүргүүлнэ. Шүүгч тогтоолыг хүлээн авснаас хойш 48 цагийн дотор шаардлагатай гэж үзвэл өмгөөлөгч, прокурорыг байлцуулан сэжигтнийг баривчлах эсэх асуудлыг шийдвэрлэж, нэн даруй захирамж гаргана” гэсэн нэмэлт, өөрчлөлт оруулсан нь ач холбогдолтой заалт болжээ.

49. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58 дугаар зүйлд “Сэжигтнийг баривчлах үндэслэл”-д “сэжигтэн оргон зугтахыг завдсан, эсхүл хүнд, онц хүнд гэмт хэрэгт сэрдэгдэх хангалттай баримт байгаа бол түүнийг баривчилж болно.” гэсэн заалтыг хэрэгжүүлэхэд арга зүйн зөвлөмж болгож “Баривчлах, цагдан хорихтой холбогдсон зарим ажиллагааг зохицуулах тухай журам”-ыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурорын 2008 оны I дүгээр 30-ны өдрийн 07/26 дугаар хамтарсан захирамж, тушаалаар, мөн Улсын дээд шүүхээс “Сэжигтнийг баривчлах, сэжигтэн, яллагдагчийг цагдан хориход анхаарах зарим асуудлын тухай зөвлөмж”-ийг 2008 оны 3 дугаар сарын 31-ний өдөр гаргасан.

50. Одоо манай улсад Цагдаагийн болон Тагнуулын байгууллага, Авлигатай тэмцэх газар Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан харьяаллын дагуу гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлж байна.

51. Тухайлбал, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар Тагнуулын байгууллага Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 20 төрлийн гэмт хэрэгтэй; Авлигатай тэмцэх газар 10 төрлийн гэмт хэрэгтэй; Цагдаагийн байгууллага Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 182 төрлийн гэмт хэрэгтэй тус тус тэмцэх чиг үүрэгтэй байна. Цагдаагийн байгууллагын харьяаллын 182 төрлийн гэмт хэргээс 30 гаруй нь хар тамхи, хүний наймаа, мөнгө угаах зэрэг үндэстэн дамнасан шинжтэй, зохион байгуулалттай, гол төлөв нууц далд аргаар үйлдэгддэг манай улсын хувьд шинэ төрлийн гэмт хэргүүд байдаг.

52. Мөрдөн шалгах ажиллагаа явуулах хэргийн харьяаллыг тогтоох, түүнчлэн шинээр байгуулагдсан Тахарын албаны хэргийн харьяаллыг тогтоох зорилгоор Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар боловсруулаад байна. УДШ-ийн Зөвлөмжийн 1 дүгээр бүлгийн 1.5 дахь хэсэгт “Шүүгч нь сэжигтнийг /хойшлуулшгүй тохиолдолд/ баривчлах тухай тогтоол хүлээн авснаас хойш 48 цагийн дотор сэжигтнийг баривчлах, эсвэл баривчлахаас татгалзах тухай захирамж гаргахдаа шаардлагатай гэж үзвэл өмгөөлөгч, прокурорыг нь байлцуулж болно” гэж дурджээ.

53. Ийнхүү сэжигтнийг ердийн журмаар төдийгүй хойшлуулшгүй тохиолдолд ч тэр баривчлахдаа заавал шүүгчийн захирамж /шийдвэр/ гаргаж, хянан үзэхээр зохицуулсан нь хүний эрхийн зарчимд нийцсэн шинэлэг зохицуулалт болжээ.

54. Нийгмээс тусгаарлах албадлагын арга хэмжээ нь захиргааны журмаар түр саатуулах, албадан саатуулах, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдийг зохих байгууллагад хүргэх ажиллагаатай нийтлэг шинжтэй боловч практикт эдгээр ажиллагаа нь дэс дараалан явагдсан тохиолдол гардаг. Тухайлбал сэжигтнийг баривчлахын өмнө түүнийг захиргааны журмаар 72 цаг саатуулсан, 7–30 хоногоор баривчлах шийтгэл хүлээлгэсний дараа тухайн зөрчил нь гэмт хэргийн шинжийг агуулсан, эсвэл зөрчил гаргасан этгээд нь урьд өмнө нь гэмт хэрэг захиргааны шийтгэл хүлээсэн этгээдийг үргэлжлүүлэн сэжигтнээр баривчлах, цагдан хорих асуудал гардаг боловч захиргааны зөрчилд нийгмээс тусгаарлагдсан хугацаа нь шалгагдсан нийт хугацаанд тооцогддоггүй байна. /Хавсралт 4/

55. Түүнчлэн сэжигтнээр тооцох үндэслэлийн нэг болох “Уг этгээдийг гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдсэн дор нь барьсан” тохиолдолд гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын албан хаагч тухайн гэмт хэрэгт сэжиглэгдсэн этгээдийг зохих

байгууллагад хүргэж өгөх хугацаанд чөлөөтэй зорчих эрхийг хязгаарлаж байгаа нь уг этгээдийг нийгмээс тусгаарлах нэг хэлбэр болж байсныг дурдах хэрэгтэй.

56. 2002 онд баталсан ЭБШ хуулийг хэрэгжүүлэх явцад хуулийг нэг мөр ойлгонхэрэглэхэд хүндрэлтэй зарим зүйл, заалтыг өөрчилжзохицуулалтыг тодорхой болгох, ерөөсөө огт зохицуулалтгүй орхигдсон харилцааг зохицуулалттай болгох шаардлагатай байгаа талаар шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудаас олон санал ирүүлж, олон улсын хүний эрхийн болон эрдэм шинжилгээ судалгааны байгууллагууд зөвлөмж болгожээ.

57. Засгийн газар эдгээр санал, зөвлөмжийг судлан үзэж, ЭБШ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулсныг Улсын Их Хурал 2007 оны 8 дугаар сарын 9–ний өдөр хуульчлан баталжээ. Энэ өөрчлөлтийг тоймлон танилцуулбал:

1. Нийгмийн эмзэг бүлгийнхэнд үзүүлэх эрх зүйн туслалцааны хүрээг өргөтгөх, тэдний өмгөөлүүлэх эрхийг баталгаажуулах зорилгоор төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч өмгөөлөгч авах хүсэлт гаргасан бол уг хэрэгт өмгөөлөгч заавал оролцуулахаар хуулийн 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт 6 дахь заалт нэмсэн.
2. Цагдан хоригдож байгаа сэжигтэн, яллагдагчийг өөр газарт шилжүүлэн хорих шийдвэрийг ямар албан тушаалтан гаргах талаар хуульд тусгаагүй байсныг прокурорын саналыг үндэслэн сэжигтэн, яллагдагчийг өөр газарт шилжүүлэн цагдан хорих асуудлыг шүүгч захирамж гарган шийдвэрлэж, сэжигтэн, яллагдагчийн гэр бүлийн гишүүн, эсхүл өмгөөлөгчид нь мэдэгдэж байхаар 68 дугаар зүйлийн 68.10 хэсгийг нэмсэн.
3. Цагдан хорих хугацааг сунгахдаа шүүгч шаардлагатай гэж үзсэн эсхүл өмгөөлөгч хүсэлт гаргасан бол өмгөөлөгч, прокурорыг байлцуулахаар хуульд 69.10 дэх хэсгийн заалтыг нэмж оруулжээ. Ингэснээр шүүх үргэлжлүүлэн цагдан хорих асуудлыг шийдвэрлэхдээ прокурор, өмгөөлөгчийн гаргасан үндэслэл, баримтад тунгуурлан бодитой хянаж шийдвэрлэх боломжтой болжээ.
4. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой шүүхийн шийдвэрт тухайн шүүхийн Ерөнхий шүүгч, эсхүл түүний эзгүйд томилсон шүүгчид гомдол гаргаж шийдвэрлүүлэхээр хуульд заасан. Харин энэ шийдвэрт дахин гомдол гаргах, эсэх талаар заалт тодорхойгүй байсныг Ерөнхий шүүгч, түүний томилсон шүүгчийн шийдвэр эцсийн байхаар нэг мөр шийдвэрлэсэн байна.
5. Хорих ангийн харьяа нутаг дэвсгэр, хилийн бүст үйлдэгдсэн гэмт хэргийг цагдаагийн байгууллага шалгахдааас өмнө хэргийн ул мөр балрах, хугацаа алдах зэрэг хэргийг илрүүлэхэд гарах хүндрэл, түүнчлэн тагнуулын байгууллагын гүйцэтгэх ажлын явцад гэмт хэргийн ул мөрийг баримтжуулах, гал түймрийн шалтгаан нөхцлийг тогтоох, гаалийн хяналт шалгалтын явцад илэрсэн гэмт хэргийг шалгаж тогтооход ач холбогдол бүхий ажиллагаа явуулах шаардлагатай байдлыг харгалзан, хорих ангийн нутаг дэвсгэрт ялтан гэмт хэрэг үйлдсэн гэх сэжиг байгаа бол хорих байгууллагын эрх бүхий албан тушаалтан, хилийн бүст гарсан гэмт хэрэгт хилийн тагнуулын алба, тагнуулын байгууллагын гүйцэтгэх ажилтан, гаалийн хяналт, шалгалтын явцад илэрсэн гэмт хэрэгт гаалийн улсын

- байцаагч, гал түймрийн шалтгаан нөхцлийг тогтоохоор гал түймэртэй тэмцэх байгууллагын эрх бүхий албан хаагч, цэрэг, цагдаагийн албан хаагч энхийг сахиулах, олон улсын бусад ажиллагаанд оролцох явцад үйлдсэн гэмт хэрэгт тухайн цэрэг, цагдаагийн багийн эрх бүхий албан тушаалтан хойшлуулшгүй ажиллагаа явуулахаар хуулийн 172 дугаар зүйлд өргөн нэмэлт оруулжээ.
6. Нэмэлт хэрэг бүртгэлт хийлгэхээр прокурорт буцаасан, түүнчлэн түдгэлзүүлсэн, хэрэгсэхгүй болгосон хэргийг сэргээсэн бол уг хэрэгт хэрэг бүртгэлт явуулах хугацааг прокурор 15 хоног хүртэл хугацаагаар сунгахаар заасан.
  7. Шүүх хэргийг хянаад урьд сонгосон ял дээр нэмж ял сонгох болон хэргийг хүндрүүлэн зүйлчлэх шаардлагатай гэж үзвэл уг үндэслэлээр шүүх хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаадаг байхаар хуульд нэмэлт оруулсан.
  8. ЭБШ хуулийн 263.3-т заасан хэргийн үнэнийг гогтооход ач холбогдолтой гэж үзвэл шүүгдэгчийг бусад шүүгдэгчийн оролцоогүй сонсож болох тухай журмыг насанд хүрээгүй шүүгдэгчид мөн адил баримтлахаар хуульд 263 дугаар зүйлийн 6 дахь заалт нэмсэн.
  9. Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, ЭБШ хуулийг ноцтой зөрчсөн гэж үзэж эрх бүхий этгээд хяналтын шатны шүүхэд гаргасан гомдол, эсэргүүцлийг Улсын дээд шүүх хяналтын журмаар хэлэлцэх хууль зүйн үндэслэл байхгүй байсныг хуулийг нэг мөр ойлгож, зөв хэрэгжүүлэх үүднээс “давж заалдах шатны шүүх хэргийг эцэслэн шийдвэрлэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн, Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзэж хяналтын шатны шүүхэд гаргасан гомдол, эсэргүүцлийг хяналтын шатны шүүх заавал хэлэлцэж шийдвэрлэх” –ээр хуулийн 342 дугаар зүйлд 2 дахь хэсэг болгон нэмсэн.
  10. Хуулийн 370 дугаар зүйлд “насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагчийн өмгөөлөгч хүсэлт гаргасан тохиолдолд байцаалтын явцыг өөрийн зардлаар дүрс бичлэгээр бэхжүүлэн авч болох 2 дахь хэсэг нэмж оруулсан нь байцаалтын явцад насанд хүрээгүй этгээдийн эрхийг зөрчихөөс сэргийлэх, гүүнчлэн байцаалтын явцыг баримтжуулах зорилготой.
  58. ЭБШХ-ийн өөрчилсөн зүйл, заалтын талаар
    1. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.11-д заасан “гэр бүлийн гишүүн” гэдэгт байцаан шийтгэх ажиллагааны гол оролцогч болох хохирогч, гэрчийн гэр бүлийн гишүүнийг хамааруулахгүй орхигдуулсаныг нөхөж томьёолсон.
    2. Хуульд иргэдийн төлөөлөгч зөвхөн шүүгдэгчийн гэм буруугийн талаар саналаа бичгээр гаргах, уг саналаа шүүх хуралдаан дээр уншиж сонсож байхаар, түүнчлэн шүүх анхан шатны журмаар хэргийг гурван шүүгчийн бүрэлдхүүнтэй хянан шийдвэрлэхдээ гурван иргэдийн төлөөлөгч оролцуулахаар хуулийн 34 дүгээр зүйлд тус тус өөрчлөлт оруулсан.
    3. Хойшлуулшгүй ажиллагаа явуулж эхэлсэн үеэс өмгөөлөгч оролцох эрхтэй байхаар хуулийн 38.3 дахь хэсгийг өөрчлөн найруулсан.
    4. Хуулийн 59.1, 68.3-т баривчлах, цагдан хорих тогтоолыг прокурор нь шүүхэд танилцуулж, шүүгч уг тогтоолыг батлахаар заасан байсныг өөрчилж Шүүхийн тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд шүүх тогтоол, шүүгч

захирамжийн хэлбэрээр шийдвэр гаргахаар заасныг үндэслэн шүүгч баривчлах, цагдан хорих эсэх талаар захирамж гаргахаар болгосон.

5. Насанд хүрээгүй яллагдагчийг хорьж мөрдөх хугацаа 18 сар хүртэл, насанд хүрсэн яллагдагчийг хорьж мөрдөж хугацааг 24 сар хүртэл сунгаж болохоор хуулийн 69, 366 дугаар зүйлүүдэд заасныг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний заалтад нийцүүлэх, хэргийг шуурхай шалган шийдвэрлэх, үндэслэлгүйгээр хүний эрхийг хязгаарлах боломжийг багасгах зорилгоор хорьж мөрдөх нийт хугацааг хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэгт ялгаатай тогтоосон өөрчлөлтийг төсөлд тусгасан.

**6 дугаар зүйл. 4–р зүйлд заасан гэмт хэргийг үйлдсэн болох нь тогтоогдсон этгээдэд байцаан шийтгэх ажиллагааг хэрхэн яаж явуулах талаар**

59. Монгол Улсын нэгдэн орсон “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын 14 зүйл, Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй болохыг баталгаажуулсан болно. Эрүүгийн хэрэгт буруутгуулсан хэн боловч гэм буруу нь хуулийн дагуу нотлогдох хүртэл гэм буруугүйд тооцогдох эрхтэй.

60. Өнгөрсөн хугацаанд Хүний эрхийн Үндэсний Комисс нийт 3229 гомдол хүлээн авснаас 70 орчим хувь буюу 2260 орчим нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаатай холбоотой байв. Үүний 13 хувь нь эрүүгийн төлөөлөгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрүү шүүлт тулгасан тухай гомдол байв.

61. Түүнчлэн баривчлах, цагдан хорих үйл ажиллагаа болон хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн ёс зүй, зан харилцаатай холбоотой гомдол 18 хувийг эзэлж байна. Тухайлбал, 2013 онд хүлээн авсан нийт 669 гомдлын 289 буюу 43.2 хувийг цагдан хоригдсон сэжигтэн, яллагдагч, хорих ял эдэлж буй ялтнуудаас гаргасан байна. Тэдгээрийн 166 гомдолд хилс хэрэгт холбогдсон, эрүү шүүлтэд өртсөн тухай дурдсан ба шалгалтаар 29 гомдол буюу 17.5 хувьнь гомдол гаргагч эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогч болсон байж болзошгүй байна гэж ХЭҮК-оос үзэж байна.

62. Улсын ерөнхий прокурорын 2014 оны 02 сарын 13–ны өдрийн А–12 дугаар тушаалд Цагдаагийн Ерөнхий газрын Мөрдөн байцаах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн газрын 6–р хэлтэс нь Улсын Ерөнхий Прокурорын газраас харьяалал тогтоосон хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна гэж заасан ба Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 02 сарын 14–ний өдрийн 95 дугаар тушаалаар Тусгай субьектын хэрэг мөрдөх хэлтэс 6 дугаар хэлтсийг байгуулав.

63. Тус хэлтэс байгуулагдсанаас хойш Улсын Ерөнхий Прокурорын газраас харьяалал тогтоосон 16 гомдол мэдээлэл хүлээн авч, 9 эрүүгийн хэрэгт хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсны 1 хэрэг нь эрүү шүүлт тулган хэрэг хүлээлгэсэн гэх хэрэг байсанд мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахад цагдаагийн алба хаагчийн гэм буруутай үйлдэл нь тогтоогдоогүй тул гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. /Хавсралт 6/

64. Монголд Улсын Их Хурлаар шинэчлэн баталсан /2013 оны 07 сарын 05/ Цагдаагийн албаны тухай хуулийн 18.2 дугаар зүйлд “. . . дотоод хяналт–аюулгүй



байдлыг хангах асуудал эрхэлсэн дэд даргатай байна.” гэж заасны дагуу ЦЕГазрын бүтцэд дотоод хяналт-аюулгүй байдлыг газрыг байгуулан ажиллаж байна.

65. 2010 онд 251, 2011 онд 237, 2012 онд 322, 2013 онд 273 хүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан ба хэрэг бүртгэгч мөрдөн байцаагч нар тогтоолгүйгээр цагдан хорьсон тохиолдол бүртгэгдээгүй байна.

66. Цагдан хорих байруудын нөхцөл байдлын талаар

Байршил, багтаамж: Улсын хэмжээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 26 цагдан хорих байр үйл ажиллагаа явуулж байгаагаас Нийслэлд цагдан хорих төв 1, аймгуудад 21 цагдан хорих байр, Сэлэнгэ аймгийн Мандал сум, Өвөрхангай аймгийн Хархорин сум, Завхан аймгийн Тосонцэнгэл сум, Багануур дүүрэгт тус бүр 1 цагдан хорих байр, Налайх дүүрэгт баривчлах байр 1 тус тус үйл ажиллагаа явуулж байна. Нийслэл дэх цагдан хорих төв 1000 хоригдогчийн, аймаг, орон нутаг дахь цагдан хорих байрууд 24–60 хоригдогчийн, Дархан-Уул аймаг дахь цагдан хорих байр 80, Төв аймаг дахь цагдан хорих байр 100, Орхон аймаг дахь цагдан хорих байр 200 хоригдогчийн багтаамжтай бөгөөд өнөөдрийн байдлаар Дорнод аймаг дахь цагдан хорих байранд 42 хоригдогчийн багтаамжтай боловч 92 хоригдогч цагдан хоригдож байгаа нь ачаалал 2 дахин өссөн буюу хэт ачаалалтай, Баянхонгор, Хөвсгөл, Архангай аймаг дахь цагдан хорих байрууд нь нэмж хоригдогч хүлээн авах боломжгүй ачаалал ихэсч хүний тоо багтаамжаас хэтэрсэн, бусад цагдан хорих байрууд хэвийн үйл ажиллагаа явуулж байна.

Цагдан хоригдогсдын тоо: Өнөөдрийн байдлаар цагдан хорих байруудад нийт 1303 /гадаад иргэн 6, Цагдан хорих 461 дүгээр ангид 4, БНХАУ–2, ОХУ–1, Бангладеш–1, Дорнод аймаг дахь шийдвэр гүйцэтгэх албанд Гүрж–1, Баян-Өлгий аймаг дахь шийдвэр гүйцэтгэх албанд Казакстан–1/ хоригдогч байгаагаас насанд хүрсэн эрэгтэй 1194, насанд хүрсэн эмэгтэй 77, насанд хүрээгүй эрэгтэй 31, насанд хүрээгүй эмэгтэй 1 хоригдогч байна. Ерөнхий газрын харьяа цагдан хорих байруудад нэг жилээс дээш хугацаанд хоригдон шалгагдаж буй 35 хоригдогч байна.

67. Жилд дунджаар 4500 орчим сэжигтэн, яллагдагч цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдан хоригддог бөгөөд 2013 оны жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр 7767 хоригдогч, 2014 оны эхний хагас жилийн байдлаар өссөн дүнгээр 4271 хоригдогч цагдан хоригджээ. Үүнээс 2013 онд 3536, 2014 оны эхний хагас жилийн байдлаар 1889 хоригдогч шүүхээс хорих болон баривчлах ялаар шийтгэгдсэн байна.

68. 2013 онд цагдан хоригдсон сэжигтэн, яллагдагч нараас шүүгчийн захирамжаар 649, баривчлах цагдан хорих байрны даргын тогтоолоор 274, 2014 оны эхний 6 сард шүүгчийн захирамжаар 298, баривчлах цагдан хорих байрны даргын тогтоолоор 193 хоригдогч тус тус суллагджээ.

**7 дугаар зүйл. Эрүү шүүлтийн гэмт хэрэгт сэжиглэгдэж буй этгээдийн хэрэгт хэрэг үүсгэн хариуцлага хүлээлгэх, уг этгээдийг шилжүүлэх асуудлаар прокурорын газар арга хэмжээ авна.**

69. НҮБ–ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны 2010 оны 11 дүгээр сарын 01–нээс 19–ний өдрийн 49 дүгээр хуралдаанаас Монгол Улсын Засгийн Газарт өгсөн зөвлөмжийн 9 дэх заалтад “Ял завших явдлыг зогсоож, эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах явдал

гаргасан төрийн албан хаагчийг буруушааж, ийм үйлдэл хийсэн хэнийг ч бай мөрдөн шалгаж, шаардлагатай бол яллах, шүүх, үйлдсэн гэмт хэргийнх ньхүнд, хөнгөнд ньтохирсон ял ногдуулж байхыг оролцогч улсаас хүсч байна. Оролцогч улс ньэрүүдэн шүүх, зүй бусаар харьцах асуудал гаргагчдыг ял завшихаас сэргийлэх үүднээс үр дүнтэй хараат бус мөрдөн шалгах механизм байгуулах хэрэгтэй байна” гэжээ.

70. НҮБ-ын Хүний эрхийн хорооны 2011 оны 2797 дахьхэлэлцүүлгээс Монгол Улсад өгсөн зөвлөмжийн 13 дахьзаалтад “Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албанд цагдаагийн ажилтны үйлдсэн бүх гэмт үйлдлийг мөрдөн шалгах бүрэн эрх, хараат бус байдал, хангалттай хөрөнгө хүч олгоход оролцогч улс анхаарна уу” гэжээ.

71. Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба нь Монгол Улсын Их Хурлын 2002 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн 47 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн 179 дүгээр тогтоолын дагуу 26 орон тоотойгоор 2002 оны 9 дүгээр сарын 11-нээс үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн түүхтэй бөгөөд Монгол Улсын Их хурлын “2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хууль, УИХ-ын 2014 оны мөн өдрийн 22 дугаар тогтоолын дагуу Авлигатай тэмцэх газар Эрүүгийн хуульд заасан 10 төрлийн хэргийг харьяалан шалгах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн бөгөөд Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албаны орон тоо, чиг үүргийн зарим хэсэг нь Авлигатай тэмцэх газарт, зарим чиг үүрэг нь Цагдаагийн байгууллагын мөрдөн байцаах албанд шилжүүлсэн.

72. Өөрөөр хэлбэл, Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албаны тагнуул, цагдаагийн байгууллагын ажилтан, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн үйлдсэн албан тушаал, авлигын гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж байсан харьяалал нь Авлигатай тэмцэх газарт шилжсэн.

73. Харин дээр дурьдсан субъектын үйлдсэн ахуйн чанартай бусад гэмт хэргийг шалгах харьяалал нь Цагдаагийн байгууллагад шилжсэн болно.

74. Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албаны ажлын тоон мэдээлэлийг хавсаргав. /хавсралт 6/

**8 дугаар зүйл. Хэрэгтэнг шилжүүлэх асуудал ямар нөхцөл байдал болон ямар хэлбэрээр тавигдах тухай мэдээлэл хангах.**

75. Монгол Улсын Үндсэн хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэнийг харьяатаас хасах, эх орноосоо хөөх, өөр улсад шилжүүлэн өгөхийг хориглоно” гэж заасан нь төрийн хувьд иргэнийхээ эрх, ашиг сонирхлыг хамгаалагч хууль зүйн гол баталгаа болдог.

76. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Монгол Улсын иргэнийг эрүүгийн хэрэгт мөрдүүлэх буюу эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр гадаад улсад шилжүүлж өгч болохгүй” гэж хуульчилсан нь Эрүүгийн хууль иргэний харьяаллаар үйлчлэх зарчмын нэг чухал баталгаа, иргэн нь өөрийн төрийн ивээлд байх энэрэнгүй ёсны зарчмын илрэл юм.

77. Эрүүгийн хууль үйлчлэх зарчмын нэг болох иргэний харьяаллаар үйлчлэх

зарчим нь Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн бүх этгээдэд энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэх агуулгатай. Бүх этгээд гэдэгт Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй этгээд хамаардаг.

78. Гэхдээ гадаад улсын дипломат дархан эрх, эрх ямба эдэлж байгаа этгээд болон тэдний гэр бүлийн гишүүд зэрэг хүмүүст эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэх асуудлыг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу шийдвэрлэдэг. Энэрэнгүй ёсны зарчим нь нэг талаас нийгмийн гишүүдийн аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах зорилтыг хангах, зөрчигдсөн эрхийг сэргээх, нөгөө талаас гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай болон энэ тухайд сэжиглэгдэн яллагдаж мөн шүүгдэж байгаа хүний эрхийг хангах гэсэн хоёр агуулгыг нэгэн зэрэг илэрхийлж байдаг өвөрмөц онцлогтой.

79. Мөн Эрүүгийн хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт “Монгол Улсын хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг эрүүгийн хариуцлага хүлээлгэх буюу ял эдлүүлэхээр Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу гадаад улсад шилжүүлж болно” гэж заасан.

80. Энэ нь гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг гэмт хэрэг үйлдсэн газрынх нь эрүүгийн хуулиар ял шийтгэх, хэргийн болон нутаг дэвсгэрийн харьяаллынх нь дагуу тухайн улс эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах үндэслэл юм.

81. Үүний тулд гадаад улсад шилжүүлж өгөх гурван үндэслэл байдаг.

- Тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх тухай олон талт хэлэлцээрт заасан үндэслэл, журмыг баримтлан шилжүүлдэг. Тухайлбал, “Төрлөөр устгах /геноцид/ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон тийм хэрэг үйлдэгчдийг цээрлүүлэх тухай” Нэгдсэн Үндэстний байгууллагын 1948 оны конвенц. Энэ тохиолдолд хэлэлцэн тохирогч талууд хууль тогтоомжийнхоо болон хүчин төгөлдөр гэрээ хэлэлцээрийнхээ дагуу гэмт хэрэгтнийг шилжүүлэх үүрэг хүлээнэ.
- Эрүүгийн хэргийн талаар туслалцаа үзүүлэх тухай олон талт конвенц, гэрээнд зааснаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлдэг. Үүнд Авилгалын эсрэг НҮБ-ын 2003 конвенци, “Барьцаанд хүмүүсийг авахтай тэмцэх тухай” 1979 оны конвенц, “Нисэх онгоцыг хууль бусаар булаан аваачих явдалтай тэмцэх тухай” 1970 оны конвенц зэрэг нь шилжүүлэн өгөх журмыг шууд зааснаараа онцгой ач холбогдолтой.
- Гэмт хэрэгтнийг шилжүүлэх болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хоёр талт гэрээнд заасны дагуу гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлдэг. Тухайлбал, “Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард улсын хоорондын гэрээ”.

82. Дээрх үндэслэлээс гадна гадаад улс орнуудад дипломат шугамаар хүсэлт гарган харилцан туслалцаа үзүүлэх хэлбэрээр гэмт этгээдийг шилжүүлж болно.

83. Харин гэмт хэрэгтнийг шилжүүлэх журмын талаар Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тусгасан. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 404 дүгээр зүйлийн 404.1 дэх хэсэгт “Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэнийхээ дараа гадаад улсад гарсан Монгол Улсын иргэнийг шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг хууль, олон улсын гэрээ, хэлэлцээрт заасан журмын дагуу гадаад улсын эрх бүхий

байгууллагад тавина” гэж заасан.

84. Монгол улсын иргэнийг шилжүүлэн өгөх тухай хүсэлт гэдэг нь Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн иргэн гадаадын аль нэг улсад байнга болон түр оршин сууж байгаа нь тодорхой бол түүнийг Монгол Улсад шилжүүлэн өгөх талаар албан ёсоор, бичгээр санал тавихыг хэлнэ.

85. Харин гадаадын эрх бүхий байгууллага гэдэг нь эрүүгийн хэргийг хянах, шийдвэрлэх эрх бүхий шүүх, прокурор, мөрдөн байцаах болон бусад эрх бүхий байгууллагыг хэлнэ.

86. Энэ нь гагцхүү Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын гэрээ хэлэлцээрт заасан журамд нийцсэн байх ёстой. Тухайлбал, “Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх” тухай Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 46 дугаар бүлэгт /мөн хуулийн 404, 405, 406, 407, 408 дугаар зүйлүүд/ эрүүгийн хариуцлагад татах болон шийтгэх тогтоол биелүүлэх зорилгоор гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай зохицуулсан байдаг.

87. Дээрх зохицуулалтад гэмт хэргийн ангилалаас үл хамааран Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсний дараа гадаад улсруу оргон зайлсан Монгол Улсын иргэнийг шилжүүлэн авах, Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн гадаадын иргэн, давхар харъяалалтай, харъяалалгүй иргэнийг шилжүүлэн өгөх эсхүл гадаад улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн Монгол Улсын иргэнийг шилжүүлэн авахад хамаарах бүхий л харилцааг хамарна. Мөн хуулийн 47 дугаар бүлэгт /мөн хуулийн 410, 411, 412, 413 дугаар зүйлүүд/ хорих ял шийтгүүлсэн этгээдийг харьяат улсад нь ял эдлүүлэхээр шилжүүлэх эсхүл шилжүүлэн өгөхөөс татгалзах харилцааг зохицуулсан.

**9 дүгээр зүйл: Байцаан шийтгэх үйл ажиллагааны ямар ч үе шатанд аливаа улс орнууд хоорондоо ижил эрх зүйн туслалцаа үзүүлэх**

88. Эрүүгийн хариуцлагад татах болон шийтгэх тогтоол биелүүлэх зорилгоор гэмт этгээдийг шилжүүлэн өгөх хүсэлтээ гадаад улсын эрх бүхий байгууллагад гаргахдаа хууль, олон улсын гэрээ, хэлэлцээрт заасан журмыг баримтална.

89. ЭБШХ-ийн 406 дугаар зүйл нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх, үндсэн эрхийг нь хамгаалсан чухал заалт юм.

90. Монгол улсын иргэн, гэмт этгээдэд Монгол Улсад орогнох эрх олгосон, гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай шаардлагын үндэслэл нь Монгол Улсад гэмт хэрэгт тооцогдохгүй, шилжүүлбэл зохих этгээд тухайн үйлдэлд урьд нь ял шийтгүүлж ялаа эдэлсэн, эсхүл уг хэргийг өмнө нь хэрэгсэхгүй болгосон, Монгол Улсын хууль тогтоомжоор тухайн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан, эсхүл бусад үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэх ял шийтгэж болохгүй нөхцөл байдал үүссэн бол иргэний харъяаллаас үл хамааран хэнийг ч өөр улсад шилжүүлж өгөхийг хориглосон.

91. ЭБШХ-ийн 410 дугаар зүйлд зааснаар хорих ял шийтгүүлсэн этгээдийг харьяат улсад нь ял эдлүүлэхээр шилжүүлэхдээ тухайн улстай байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээнд заасан нөхцөл журмын дагуу гүйцэтгэх бөгөөд хууль, Монгол улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын шүүхээр хорих ял шийтгүүлсэн этгээдийг харьяат улсад нь шилжүүлэн өгөх шийдвэрийг Улсын Ерөнхий прокурор гаргана.

92. Монгол Улстай байгуулсан хоёр талт гэрээний хувьд нийтлэг шинжээс гадна

дараах онцлог талууд байна. Бүгд Найрамдах Хятад Ард Улс: Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх хүсэлт нь шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэхтэй холбоотой бөгөөд уг тогтоолоор оногдуулсан ялын үлдсэн хугацаа нь 6 сараас дээш бол гэмт этгээдийг шилжүүлж болохоор байна.

93. Гэмт этгээдийг шилжүүлэн өгөхөөс татгалзах үндэслэлд эрэн сурвалжлагдаж байгаа этгээдийг арьс өнгө, шашин шүтлэг, иргэний харьяалал, хүйс, эсхүл улс төрийн үзэл бодлоор нь ял шийтгэх гэж байгаа, эсхүл шүүн таслах ажиллагааны үеэр дээрх шалтгаанаар хохироох бодитой үндэслэлтэй гэж үзсэн, хүсэлт гаргагч талын улсын хууль тогтоомжийн дагуу зөвхөн цэргийн гэмт хэрэгт хамаардаг, хүсэлт хүлээн авагч талын хууль тогтоомжийн дагуу тухайн улсын шүүн таслах харьяалалд хамаардаг, үүнтэй холбогдуулан эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж байгаа зэрэг тохиолдлууд багтаж байна.

94. Хүсэлт гаргагч тал нь шилжүүлэн авсан этгээдийг эрүүгийн хариуцлагад татсан буюу түүнд оногдуулсан ял шийтгэлийг биелүүлсэнтэй холбогдсон, эсхүл гуравдагч улсад дамжуулан шилжүүлсэн талаарх мэдээллийг хүсэлт хүлээн авсан талд цаг тухайд нь мэдэгдэх ёстой байна.

95. Бүгд Найрамдах Энэтхэг Улс: Шилжүүлэн өгөх гэмт хэрэгт орлогын татвар, санхүүгийн шинжтэй гэмт хэргийг оруулсан байна. Мөн хуйвалдах, өдөөн хатгах, завдах, хамтран оролцох болон нутаг дэвсгэрийн нэмэлт харьяалал бүхий гэмт хэрэг үйлдвэл гэмт хэрэг үйлдсэн тооцохоор байна. Хүсэлт хүлээн авсан талын хуулиар шилжүүлэн өгөхийг зөвшөөрдөггүй, эсхүл тухайн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг нь цэргийн гэмт хэрэг бол шилжүүлэн өгөхөөс татгалздаг.

96. Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх хүсэлт гаргасан талын хуулиар уг этгээл цаазаар авах ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэн нь хүсэлт хүлээн авагч талын хуулиар тус гэмт хэрэгт цаазаар авах ял оногдуулахааргүй байвал хүсэлт гаргасан тал цаазаар авах ял оногдуулахгүй гэсэн хангалттай баталгаа гаргаж өгөхгүй бол шилжүүлэн өгөхөөс татгалзахаар байна.

**10-р зүйл: Хууль сахиулах байгууллагын энгийн буюу цэрэгжсэн ажилтан, эмнэлгийн ажилтан, төрийн албан тушаалтан болон бусад хүнийг бэлтгэх сургалтын хөтөлбөр**

97. Хууль сахиулахын их сургуулийн цагдаагийн сургуулийн хичээл сургалтын хөтөлбөрт “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийн эсрэг” Нэгдсэн Үндэсний Байгууллагын конвенцийн агуулга, үзэл санаа, “Эрүүдэн шүүлтийг урьдчилан сэргийлэх” арга замыг танин мэдэх асуудал сэдвүүд бүрэн тусгагдсан байна. Хөтөлбөрийн дагуу 2008–2013 онуудад нийт 161 дамжааны 4909 сонсогч, суралцагчдад сургалт хийсэн байна.

98. Хууль Сахиулахын Их Сургуулийн цагдаагийн сургуулийн сонсогч нар батлагдсан хичээлийн хөтөлбөрийн дагуу зохих түвшний багц цагийг хангах хүний эрхийг дээдлэх, хамгаалах, эрхийг нь эдлүүлэх мэдлэг чадварыг эзэмшин төгсөж байна.

99. Цагдаагийн ерөнхий газрын дэмжлэг үзүүлэх мэргэжлийн газрын сургалт дадлагын төвд дээрх хугацаанд “Гэрч хохирогч, сэжигтэн яллагдагчтай харилцах ажиллагаа анхаарах асуудал”, “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад гардаг

мэргэжлийн алдаа, урьдчилан сэргийлэх асуудал”, “Гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны явцад хүний эрхийг хангах”, “Зөрчил гаргасан, саатуулагдсан иргэдтэй харилцах, үйлчилгээ үзүүлэхэд анхаарах асуудал”, “Зөрчилдөөний шийдвэрлэх арга тактик”, “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад сэжигтэн, яллагдагч нарын эрхийг хангах нь” сэдвүүдээр нийт 8 удаа 32 цагийн сургалт зохион байгуулж хэрэг бүртгэх мөрдөн байцаах эрх бүхий 521 алба хаагч хамрагджээ.

100. Мөн өөрсдийн дотоод нөөц бололцоонд тулгуурлан “Сургагч багш” бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд “Эмнести интернэйшнэл” олон улсын байгууллагатай хамтран хүний эрхийн сургалтыг тусгайлан оруулж “Эрүүдэн шүүлт ба хүний эрх”, “Хүний эрхийн хязгаарлалт” сэдвээр давхардсан тоогоор 82 сургагч багшид 16 цагийн сургалт зохион байгуулсан байна.

101. Орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдээс эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогч нарын эрхийг хангах чиглэлээр Хүйсийн тэгш эрхийн төв, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, хүний эрх хөгжил төв, Хүний эрхийн үндэсний төв зэрэг төрийн болон төрийн бу байгууллагуудтай хамтран жил бүр 1–ээс доошгүй удаагийн сургалт авч алба хаагч нарыг бүрэн хамруулж ажиллав.

## **11–р зүйл: Эрүү шүүлт болон бусад түүний ижил үйлдлээс**

### **урьдчилан сэргийлэх ажлын хяналт**

102. Гэмт хэргийн хохирогч, гэрч нарын аюулгүй байдлыг хангах сэтгэл санааны дарамтанд орж, айж сандарсан хохирогчийг сэжигтэн этгээдтэй уулзуулахгүйгээр байцаан шийтгэх ажиллагааг явуулах, сэжигтэн, яллагдагчид эрүү шүүлт тулгах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдэд байцаалтын өрөө, таньж олуулах, хяналтын өрөө гарган бүрэн тоноглож тохижуулах ажлыг орон нутагт зохион байгуулав.

103. Нийслэлийн зарим дүүргийн цагдаагийн хэлтсүүдэд тусгай өрөө гаргах боломж муу байгаатай холбоотойгоор хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын өрөөнд хяналтын камер суурилуулан үйл ажиллагаандаа ашиглаж байна.

104. Эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх, баривчлагдсан, саатуулагдсан, хоригдсон хүмүүсийг байцаахтай холбогдсон журам, зааврыг хэрэгжүүлэх, цагдаагийн алба хаагч нараас тэдэнтэй хэрхэн харилцаж байгаад хяналт тавин ажиллаж байна.

105. Мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн газрын уулзалт байцаалтын хэсэгт давхардсан тоогоор 2579 эрх бүхий /хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч, тагнуулын болон авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагч/ нараас нийт 3150 сэжигтэн яллагдагчтай уулзах, байцаалт авах ажиллагааг байцаан шийтгэх ажиллагааны оролцогч нарын аюулгүй байдлыг хангах, хяналт хамгаалалт, нууцлал, дэг журмыг сахиулах үүргийг гүйцэтгэсэн ба эрүүдэн шүүх болон хүнлэг бус харьцах тохиолдол гараагүй байна.

106. “Хорих газар дахь нас баралтыг мөрдөн байцаах” заалтын хүрээнд 2008–2013 онуудад ШШГЕГ азрын хорих ангиудад нийт 108 ялтан нас барсан тохиолдол бүртгэгдсэнийг эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж, холбогдох ажиллагааг явуулж, хэргийг шалгаж шийдвэрлэв.

107. Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлд “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэж хуульчилсан. Гэтэл Улсын ерөнхий прокурор дэргэдээ Мөрдөн байцаах алба байгуулсан нь Үндсэн хуулийн уг заалттай зөрчилдөж байсан тул Үндсэн хууль зөрчсөн заалтыг Монгол Улсын Их Хурлаас хүчингүй болгосон.

108. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Авлигатай тэмцэх газар нь Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албаны харьяалан шалгаж байсан хэргүүдээс зөвхөн өөрийн харьяалан шалгадаг авлига, албан тушаалын гэмт хэргийг тагнуул, цагдаагийн байгууллагын ажилтан, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч үйлдсэн тохиолдолд мөрдөн байцаах ажиллагаа явуулж байна, өөрөөр хэлбэл, АТГ-ын харьяалан шалгадаг гэмт хэргийг дээр дурдсан субъект үйлдсэн бол Авлигатай тэмцэх газар бус Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба шалгадаг ойлгомжгүй тогтолцоо бүрдсэн байсныг хууль тогтоогчид өөрчилж чадсан.

109. Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтэс нь тагнуул, цагдаагийн байгууллагын ажилтан, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчээс бусад албан тушаалтны үйлдсэн албан тушаал, авлигын гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж байсан учраас шинэ зүйл биш юм. 2007 оны 9 дүгээр сарын 7-ны өдрөөс 2010 оны 10 сарын 7-ны өдрийг хүртэлх хугацаанд Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтэс нь тагнуул, цагдаагийн байгууллагын ажилтан, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн үйлдсэн авлига, албан тушаалын гэмт хэрэгт хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтыг явуулж байсан бөгөөд Монгол Улсын Ерөнхий прокурорын 2010 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 170 тоот тушаалаартагнуул, цагдаагийн байгууллагын ажилтан, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн үйлдсэн авлига, албан тушаалын гэмт хэрэгт хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтыг Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албанд харьяалуулсныг Монгол Улсын Их Хурлаас хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар Авлигатай тэмцэх газарт мөрдөн байцаалтын харьяалал буцаж ирсэн юм.

110. Олон улсын жишгээс үзэхэд гэмт хэргийг шалгах харьяаллыг зөвхөн хуулиар, тэр дотроо төрөл, зүйл ангиар нь тогтоож өгсөн байдаг. Харин тодорхой үйлдэгдсэн гэмт хэрэг нь хэд хэдэн аймаг, сум дамнасан олон үйлдэлтэй байх тохиолдолд прокурор хаана шалгах нь тохиромжтой байгааг харгалзан харьяаллыг тогтоох эрх нь нээлттэй байдаг.

111. Ийнхүү төрийн тусгай албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах харьяаллыг өөрчлөн тогтоосноор Прокурорын хяналтын чиг үүрэгт ямарч өөрчлөлт ороогүйг тэмдэглэх нь зүйтэй. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаатай холбоотой гомдол гарвал прокурор аль ч шатанд хянах, харьяаллыг өөрчлөн тогтоож зохицуулах эрх нь нээлттэй байгаа.

112. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага дэргэдээ Мөрдөн байцаах албатай, тус алба нь тагнуул, цагдаагийн байгууллагын ажилтан, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч үйлдсэн ахуйн

шинжтэй гэмт хэргээс эхлэн авлига, албан тушаалын хэргийг шалгаж, прокурор нь өөрийн мөрдөн байцаагчдын ажиллагаанд хяналт тавьж байсан нь мөрдөн байцаагчид нөлөөнд автах, хараат бус байдалд нь сөргөөр нөлөөлөх, ашиг сонирхлын зөрчил үүсэх үр дагаврыг дагуулах эрсдэлтэй байсны зэрэгцээ тэрээр гүйцэтгэх ажил явуулах эрхгүй байсан тул авлига, албан тушаалын хэргийг илрүүлэх боломж хязгаарлагдмал байсан болно.

113. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого үйл ажиллагааны хөтөлбөрийн “Хуулийн засаглалтай улс” бүлгийн 1.3–т “Авлига, хээл хахууль, төрийн хүнд суртал, албан тушаалтнуудын хууль бус үйл ажиллагаатай үргэлжлүүлэн тэмцэнэ. Хууль зөрчигчидтэй хөрөнгө чинээ, нам улс төр, танил тал харгалзахгүй ижил тэгш хариуцлага тооцож ажилладаг жишгийг хуульчлан тогтоож хэрэгжүүлнэ” гэж, 1.4–т “Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчныг үргэлжлүүлэн боловсронгуй болгоно.” гэсэн зорилтуудыг тус тус дэвшүүлсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2012–2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт “Авлига, хүнд сурталтай хийх тэмцэлд эрс шинэчлэл гаргах”–аар тус тус зорилго болгосон байдаг.

114. Эдгээр баримт бичгүүдэд тусгагдсан зорилт, зорилгыг хэрэгжүүлж байгаа нэг хэлбэр бол яах аргагүй холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж авлига, албан тушаалын хэргийг нэг байгууллага шалгах бололцоо нөхцөлийг нэмэгдүүлж байгаа явдал мөн.

115. Засгийн газрын 2012–2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “мөрдөн байцаах, эрүүгийн цагдаагийн байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг Мөрдөх алба болгон нэгтгэн зохион байгуулж, тус албаны дэргэд Шүүхийн шинжилгээний бүтцийг бий болгох”–оор зорилт дэвшүүлэн үүний дагуу хууль зүйн салбарын шинэчлэл хийгдэж байгаа бөгөөд энэ хүрээнд Мөрдөх албаны тухай хуулийн төслийг боловсруулан УИХ–д өргөн барьсан билээ.

116. Мөрдөн байцаах ажиллагаа явуулдаг байгууллагыг цөөрүүлэх бодлогын хүрээнд шинэчлэл хийхээр зорьж байгаа энэ цаг үед Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албыг Авлигатай тэмцэх газарт нэгтгэсэн буюу мөрдөн байцаах ажиллагаа явуулдаг байгууллагыг нэгээр цөөрүүлж, Авлигатай тэмцэх газрын харьяалан шалгадаг хэргийг нэмэгдүүлсэн нь хууль зүйн салбарын шинэчлэлийн угтвар нөхцөлийн нэг болж байна.

117. Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсүүд иргэдэд үйлчлэх танхим байгуулан өмгөөлөгчдийн холбоо болон тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг өмгөөлөгч нарын байршил, утасны дугаар зэргийг байрлуулсан ба цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг таниулах, шаардлагатай хууль эрх зүйн мэдлэг олгох зорилгоор цахим болон мэдээллийн самбарыг ажиллуулан эрх зүйн туслалцаа авах боломжийг бүрдүүлэв.

118. Аймаг орон нутагт иргэдээс цагдаагийн алба хаагчийн хууль бус үйлдэл, хүнлэг бус харилцааны талаар гомдол мэдээлэл хүлээн авах зорилгоор суурин утас ажилуулж, цагдаагийн газар хэлтсийн цахим хаягийг иргэдэд сурталчилан мэдээ мэдээлэл хүлээж аван ажиллаж байна. Орон нутгийн бүх цагдаагийн газар хэлтсүүд цахим хаягтай болсон.

119. Эрүү шүүлт тулгах, харгис хэрцгий, хүнлэг бус харилцаа, бусдын нэр төрийг



гутаан доромжлохоос урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын 2013 оны 03 дугаар сарын 25–ны өдрийн 3/207 дугаартай зөвлөмж, Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газраас хүргүүлсэн 04 дүгээр сарын 09–ний өдрийн 3/1788 дугаартай үүргийг цагдаагийн нийт алба хаагч нарт танилцуулан хэрэгжүүлж ажиллах талаар хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий алба хаагч нараас баталгаа бичүүлэн ажиллаж байна.

**12–р зүйл: Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий  
хандах явдлыг мөрдөн байцаах**

120. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 27 дугаар зүйлд заасан харьяаллаар эрүү шүүлт тулгах гэмт хэргийг тухайн нутаг дэвсгэрийг хариуцсан Цагдаагийн газар, хэлтсийн мөрдөн байцаагч шалгах аар болсон. Татан буугдсан Мөрдөн Байцаах Албаны тоон мэдээнээс харахад гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 90 гаран хувь нь цагдаагийн байгууллагын ажилтантай холбоотой байна. 2007–2012 онд тус Албанаас хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэрэгт холбогдогчоор нь авч үзвэл шүүгч 25, прокурор 26, мөрдөн байцаагч 115, хэрэг бүртгэгч 108, цагдаагийн байгууллагын бусад ажилтан 1094, тагнуулын байгууллагын ажилтан 39 холбогджээ.

121. 2007–2012 оны байдлаар эрүү шүүлт тулгасан гэх гомдол мэдээллийг шалгасан байдлыг судлахад эрүү шүүлт тулгасан нь тогтоогдоогүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон 14, гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон боловч өршөөлийн тухай хуулиар хэрэгсэхгүй болсон 5, шүүхээр ял шийтгүүлсэн 5, харьцааны зөрчил гаргасан болон бусад үндэслэлээр 15 гомдол мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан байна.

122. Хүний эрхийн үндэсний комисс нь 2013 онд нийт 650 гомдол хүлээж авч шийдвэрлэжээ. Үүнээс 289 нь хорих буюу цагдан хорих байгууллагад хоригдож байгаа хүмүүсээс ирүүлсэн гомдол байсан аж. Он гарсаар 282 гомдол хүлээн авсны 134 нь хорих анги, цагдан хорих байгууллагад хоригдож байгаа хүмүүсээс иржээ. Энэ нь цаашид өсөх хандлагатай байна.

123. Сүүлийн жилүүдэд ирүүлж байгаа өргөдөл гомдол нь эрүүдэн шүүх, нэр төрийг нь доромжлон харьцаж байгаа талаар дурдах болсон. Тиймээс ХЭҮК хорих ангиудад байнгын шалгалт болон сургалт зохион байгуулдаг байна.

124. Цаашид Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколд нэгдэн орох асуудлыг судлан шийдвэрлэж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн. Энэ хүрээнд Тахарын албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөх эрхийг тус албанд шилжүүлэх боломжийг судалж байна.

**13–р зүйл: Эрүүдэн шүүгдсэн этгээдэд гомдол гаргах эрхийг нь хангасан байдал**

125. Монгол Улсын УИХ–ын чуулганаар 2013 онд батлагдсан Төлбөрийн чадваргүй яллагдагчид эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хууль нь 2014 оны 1 дүгээр сарын 1–ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн.

126. Энэ хүрээнд Хууль зүйн сайд, Сангийн сайд нарын хамтарсан 2014 оны 01 сарын 20-ны өдрийн А/05/8 дугаар тушаалаар Хууль зүйн туслалцааны төвийн салбаруудын орон тоо, байршлыг баталсан. Хууль зүйн туслалцааны төв нь ажлын алба, 32 салбартайгаар улсын хэмжээнд нийслэлийн 9 дүүрэг, 21 аймаг болон 3 суманд төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг явуулж байна.Одоогийн байдлаар төвд ажлын албаны 9 албан хаагч, 47 улсын өмгөөлөгч, 4 өмгөөлөгчийн туслах ажиллаж эхлээд байна. /Хавсралт 7,8,9/

127. Хууль зүйн туслалцааны төвд 2014 оны 2–6 дугаар сард нийт 982 хэргийн 1046 холбогдогч үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ авахаар хандсан байна. Үүнээс 479 хэргийг шүүхээр бүрэн шийдвэрлэж, шүүхийн өмнөх шатанд 66 хэргийг шийдвэрлэн, 358 хэрэг шийдвэрлэх шатанд байна. Мөн нийт хандсан иргэдээс харьяаллын бус, төлбөрийн чадвартай нь тогтоогдсон, өмгөөлөгчөөс татгалзсан зэрэг шалтгаанаар 79 хэрэг татгалзагдсан. Үүнд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхээс төлбөрийн чадвартай болох нь тогтоогдсон 37 хэрэг, харьяаллын биш 24 хэрэг, өмгөөлөгчөөс татгалзсан 9 хэрэг, бусад шалтгаанаар 9 хэргийн холбогдогчид өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзсан байна.

128. Хууль зүйн туслалцааны төвийн салбарын улсын өмгөөлөгчид 2128 иргэнд хууль зүйн зөвлөгөө өгч ажиллажээ. Тухайлбал, Баян-Өлгий, Увс, Говь-Алтай, Дундговь аймаг, Налайх, Хан-Уул, Баянзүрх дүүргийн туслалцааны төвүүд хамгийн олон иргэнд хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгч тусалжээ. 2014 оны эхний 4 сарын мэдээнээс үзэхэд нэг өмгөөлөгчид ноогдох хэргийн тоо сард дунджаар 5–6 орчим байна. Энэ үзүүлэлт цаашид нэмэгдэх хандлагатай байгаа болно.

129. Дээрх хүснэгтээс дүгнэхэд үйлчлүүлэгчдийн дийлэнх хувь нь мөрдөн байцаалтын (49.2%) болон анхан шатны шүүхийн шатнаас (28.3%) өмгөөллийн туслалцаа авахаар хандсан байна. Улсын өмгөөлөгчдийн шүүхээр шийдвэрлүүлсэн хэргийг ангиллаар нь авч үзвэл:

- онц хүнд гэмт хэрэг 41 буюу 7,5%–ийг,
- хүнд гэмт хэрэг 93 буюу 17%–ийг,
- хүндэвтэр гэмт хэрэг 342 буюу 62.7%–ийг
- хөнгөн гэмт хэрэг 76 буюу 13.9%–ийг тус тус эзэлжээ. /хавсралт 7/ Хууль зүйн туслалцаа авсан эрүүгийн хэргийн дийлэнх хувийг /62.7%/ хүндэвтэр хэрэг эзэлж байна.

130. Хууль зүйн туслалцаа авсан гэмт хэргийг төрлөөр нь харьцуулвал, бусдын эд хөрөнгийг хулгайлах /53,3%/, бусдын бие, махбодид хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл санаатай учруулах /20,1%/, танхайрах гэмт хэрэг /10%/ байна. /Хавсралт 8/ Дээр дурдсан тоон үзүүлэлтээс харахад өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг дийлэнх хувийг эзэлж байна. Гэмт хэрэгт холбогдож байгаа төлбөрийн чадваргүй иргэд ихэвчлэн эрхэлсэн тодорхой ажилгүй, тогтмол орлогогүй, ам бүл олон өрхийн гишүүн байна.

131. Улсын өмгөөлөгчийн үйл ажиллагааны хүртээмж, энэ талаарх мэдээлэл олон нийтэд хүрсэн эсэх, ихэвчлэн хаанаас улсын өмгөөлөгчид хандаж байгаа талаар судлан үзэхэд тухайн үйлчлүүлэгч болон түүний төлөөллийн хүн улсын өмгөөлөгчид шууд биечлэн хандаж байна. Нийт үйлчлүүлэгчдийн 43% нь шууд ханджээ. Түүнчлэн шүүх, мөрдөн байцаах, цагдан хорих байгууллага зэрэг хууль хяналтын байгууллагууд төвийн

Ажлын албанд хандан өмгөөлөгч томилуулах хүсэлт их гаргаж байна. /Хавсралт 9/

132. Цагдаагийн ерөнхий газрын дотоод хяналт аюулгүй байдлын газар нь иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдлыг хүлээн авч шалгалтын ажиллагааг явуулдаг бөгөөд 2008–2013 оны хооронд иргэд, байгууллагаас “цагдаагийн алба хаагч нь эрүүдэн шүүж хэрэг хүлээлгэсэн” гэсэн өргөдөл, гомдол бүртгэгдээгүй байна.

133. Улсын гэмт хэргийн сангаас шүүж үзэхэд: хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, тарчилган зовоох, тохуурхан даажигнах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэж мэдүүлэг өгөхийг албадан эрүү шүүлт тулгасан гэмт хэрэг 2010 онд 1, 2011 онд 9, 2012 онд 1, 2013 онд 1 бүртгэгдэж Шүүхээр шийдвэрлэгдсэн байна. Нийслэлд 5, Увс 3, Дорноговь, Сэлэнгэ, Хэнтий, Ховд аймагт тус бүр 1 гэмт хэрэг тус тус бүртгэгджээ.

#### **Зүйл 14. Хууль бус эрүү шүүлтэд өртсөн хохирогчдын хохирлыг шударгаар шийдэх, нөхөн төлбөр**

- “Хууль бусаар баривчлагдаж эсхүл цагдан хоригдож хохирсон этгээд хохирлоо албадан нөхөн төлүүлэх эрхтэй.”

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын  
9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг

- “Оролцогч улс өөрийн эрх зүйн тогтолцоогоороо эрүүдэн шүүгдсэн этгээд хохирлоо арилгуулах, шударга, хангалттай нөхөн төлбөр авах эрх, түүний дотор эрүүл мэндээ бүрэн сэргээхэд шаардлагатай төлбөр гаргуулах эрхийг хүлээн зөвшөөрнө. Эрүүдэн шүүгдсэний улмаас хохирогч нас барвал асран халамжлагч нөхөн төлбөр авах эрхтэй.”

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг

134. гэж заасан нь эрүү шүүлтийн улмаас учирсан хохирол, эрүүл мэнд, сэтгэл санааны нөхөн төлбөр авах эрхийг баталгаажуулсан байна. НҮБ–аас батлан гаргасан “Гэмт хэргийн болон эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас хохирсон хүмүүсийн эрх зүйн хамгаалалтыг хангах үндсэн зарчмууд”–ын 3.3.–т төрийн албан тушаалтан болон төрийг төлөөлж албан үүрэг гүйцэтгэж буй этгээд үндэснийхээ хууль тогтоомжийг зөрчиж, эрх мэдлээ урвуулан болон хэтрүүлэн ашигласан бол хохирогч төрөөс нөхөн төлбөр авах эрхтэй байна.

135. Тухайн хохирлыг хариуцах засгийн газар нь өөрчлөгдсөн тохиолдолд тухайн асуудлыг хариуцах байгууллага хохирлыг барагдуулна хэмээн заажээ. Тиймээс олон улсын эрх зүйн зохицуулалтаар эрүү шүүлтийн улмаас учирсан хохирлыг шударгаар, хангалттай нөхөн төлөх үүргийг Монгол Улсын Засгийн газар хүлээж байна. Өөрөөр хэлбэл эрүү шүүлтийн улмаас учирсан хохирлыг төр хариуцан арилгах үүрэгтэй.

136. Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт “... бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх...” гэж хохирол нөхөн төлүүлэх эрхийг баталгаажуулсан.

137. Хохирол нөхөн барагдуулсан байдал: Дээрх хуулийн заалтын хэрэгжилт практикт хангалтгүй, мөн төсвийн байгууллагад шүүхийн шийдвэрээр тогтоосон төлбөрийг барагдуулахад зориулан хөрөнгө тусгайлан төсөвлөн олгогдоггүйгээс энэ төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа 2009 он хүртэл зогсонги байдалд орж, төсвийн байгууллагын төлбөрийн гүйцэтгэх баримт бичиг 1996 оноос хойш ихээр хуримтлагдаж, шүүхийн шийдвэртэй төлбөр он дамжин үргэлжилж, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхэд хүндрэлтэй нөхцөл байдлыг үүсгэсэн.

138. Засгийн газрын тогтоолоор 2008 онд 16 иргэнд 183.2 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгуулсан. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад учирсан хохирлыг Засгийн газрын тусгай сангийн хуульд заасны дагуу Засгийн газрын нөөц сангаас гаргуулахаар шүүхээс шийдвэрлэж байгаа ч уг төлбөрийг төрийн байгууллага, албан хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг барагдуулах ажлын хүрээнд нэгтгэн шийдвэрлэж Хууль зүйн сайдын тухайн жилийн төсөвт тусган, гүйцэтгэлийг хангаж байгаа болно.

139. Уг ажлын хүрээнд 2008–2014 оны 9 дүгээр сарын 10–ны байдлаар 41.1 тэрбум төгрөгийг төрөөс олгох ажиллагаа явагдснаас 403 иргэнд 7.7 тэрбум төгрөг олгогдсон бөгөөд үүнээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явцад буюу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн буруутай үйл ажиллагааны улмаас хохирсон 137 иргэнд 1.5 тэрбум төгрөг */энэ дүн иргэнд олгосон төлбөрийн дүнд багтана/* мөн 234 хуулийн этгээдэд 33.4 тэрбум төгрөгийн төлбөрийг шүүхийн шийдвэрийг үндэслэн төрөөс олгох ажиллагаа явагдсан.

140. Дээрх мөнгөн хөрөнгийн хуваарилалтыг жилд олгосон хэмжээгээр харуулбал:

1. 2008 онд эрүүгийн хэргийн улмаас хохирсон 16 иргэнд 183.2 сая төгрөгийг,

2. 2009 онд Хууль зүйн сайдын төсөвт 3.4 тэрбум төгрөгийн тусгуулснаар уг мөнгөн хөрөнгийг 132 иргэн, хуулийн этгээдэд хуваарилан олгосон.

2011 онд Хууль зүйн сайдын төсөвт 11.7 тэрбум төгрөгийн тусгуулснаар уг мөнгөн хөрөнгийг 65 иргэн, хуулийн этгээдэд хуваарилан олгосон. Үүнд:

- 30 иргэнд 229.4 сая төгрөгийг олгосон бөгөөд үүнээс эрүүгийн хэргийн улмаас хохирсон 3 иргэнд 11.7 сая төгрөгийг,

- 35 хуулийн этгээдэд 11.5 тэрбум төгрөгийг олгосон.

2012 онд Хууль зүйн сайдын төсөвт 12.0 тэрбум төгрөгийн тусгуулснаар уг мөнгөн хөрөнгийг 240 иргэн, хуулийн этгээдэд хуваарилан олгосон. Үүнд:

- 165 иргэнд 4.3 тэрбум төгрөгийг олгосон бөгөөд үүнээс эрүүгийн хэргийн улмаас хохирсон 44 иргэнд 417.8 сая төгрөгийг,

- 75 хуулийн этгээдэд 7.7 тэрбум төгрөгийг олгосон.

2013 онд Хууль зүйн сайдын төсөвт 6.7 тэрбум төгрөгийн тусгуулснаар уг мөнгөн хөрөнгийг 61 иргэн, хуулийн этгээдэд хуваарилан олгосон. Үүнд:

- 46 иргэнд 542.3 сая төгрөгийг олгосон бөгөөд үүнээс эрүүгийн хэргийн улмаас хохирсон 30 иргэнд 484.4 сая төгрөгийг,

- 15 хуулийн этгээдэд 6.2 тэрбум төгрөгийг олгосон.

2014 онд Хууль зүйн сайдын төсөвт 6.7 тэрбум төгрөгийн тусгуулснаар уг мөнгөн хөрөнгийг хуваарилах ажиллагаа явагдаж байгаа болно. Үүнд:

- 29 иргэнд 1.6 тэрбум төгрөгийг олгосон бөгөөд үүнээс эрүүгийн хэргийн улмаас хохирсон 9 иргэнд 108.2 сая төгрөгийг,
- 11 хуулийн этгээдэд 4.5 тэрбум төгрөгийг олгох ажиллагаа явагдаж, төсөвт тусгагдсан үлдэгдэл хөрөнгийн хуваарилалт одоогоор шийдвэрлэгдээгүй байна.

141. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын нэхэмжлэл: Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1. дэх хэсэгт “аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах, шүүх хуралдаанд хуулиар тогтоосон журмын дагуу биечлэн болон төлөөлөгчөө оролцуулах,” гэж заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комисс нь эрүү шүүлтэд өртсөн хилс хэрэгт шалгагдсан, хоригдсон хүнд учирсан хохирогчдын хохирлыг төрөөс нэхэмжилж, шүүхийн практик тогтоосон байна.

142. Комисс 2001 онд байгуулагдсан бөгөөд өнгөрсөн хугацаанд нийт 24 нэхэмжлэл шүүхэд гаргасан боловч шүүх сэтгэл санааны болон эрүүл мэндийн хохирлыг ихэнхдээ хэрэгсэхгүй болгож, цөөхөн тохиолдолд маш багаар тогтоож шийдвэрлэсэн байдаг. Хилс хэрэгт холбогдсон, эрүү шүүлтэд өртсөний улмаас учирсан хохирлыг арилгуулахаар Комисс Засгийн газраас 1'021'322'000 төгрөг нэхэмжилсэн боловч шүүх 209'475'149 төгрөгийг буюу 21 орчим хувийг хангаж шийдвэрлэсэн юм.

#### **Зүйл 15. Шүүх хуралд хэрэглэгдэхгүй мэдээ баримтуудыг төр нь баталгаажуулах ёстой**

143. Тайлангийн хугацаанд Эрүүгийн байцаан шийтгэх хуульд 2008 он, 2014 онд томоохон хэмжээний өөрчлөлт оруулсан байна. Энэ нь хүний эрхийг хуульчлан баталгаажуулахад чиглэсэн заалтууд байсан.

Нотлох баримттай холбоотой Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд шинээр орсон нэмэлт, өөрчлөлтийг дурдвал: Тус хуулийн 7 дугаар зүйл. Шүүн таслах ажиллагааг талуудын эрх тэгш байдал, мэтгэлцээний үндсэн дээр явуулах 17.1. Шүүн таслах ажиллагаа нь эрх тэгш бүхий яллах, өмгөөлөх талын мэтгэлцээний үндсэн дээр явагдана. Анхан шатны шүүхийн шүүн таслах ажиллагааны мэтгэлцэх зарчмыг хангахдаа шүүх хуралдаанд талууд, тэдгээрийн өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч болон улсын яллагчид асуулт асуух, хариулах, нотлох баримтыг танилцуулах, өөрсдийн тайлбар өгөх, үндэслэлээ хамгаалах, үгүйсгэх боломжийг тэгш олгоно. /Энэ хэсгийн 2 дахь өгүүлбэрийг 2014 оны 4 дүгээр сарын 24–ний өдрийн хуулиар нэмсэн/

49 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд шүүгч оролцож болохгүй үндэслэл

49.1.5. ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал байгаа бол. /Энэ заалтыг 2014 оны 4 дүгээр сарын 24–ний өдрийн хуулиар нэмсэн/

79 дүгээр зүйл. Нотлох баримт

79.1. Гэмт хэргийн нөхцөл байдлын талаар хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан баримт сэлт, мэдээллийг нотлох баримт гэнэ. /Энэ хэсэгт 2009 оны 12 дугаар сарын 3–ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

134 дүгээр зүйл. Эд хөрөнгө битүүмжлэх

134.1.Иргэний нэхэмжлэл болон эд хөрөнгө хурааж болзошгүй явдлыг хангах зорилгоор яллагдагч, сэжигтэн, эсхүл хуулиар тэдний өмнөөс эд хөрөнгийн хариуцлага хүлээвэл зохих хүний эд хөрөнгийг битүүмжлэх, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого гэдгийг нотлох хангалттай үндэслэл байгаа бол уг хөрөнгө, орлогыг битүүмжлэх үүрэгтэй. /Энэ хэсгийг 2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

134.11.Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг битүүмжлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд тухайн гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг эзэмшигч нь тодорхойгүй, эсхүл эзэмшигчид мэдэгдэх нь тус үйл ажиллагааны зорилгод хор хохирол учруулахаар бол эзэмшигч, өмчлөгчид урьдчилан мэдэгдэхгүй байж болно.

/Энэ хэсгийг 2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн/

208 дугаар зүйл. Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэл

208.1.Дор дурдсан үндэслэлээр эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгоно:

208.1.1.энэ хуулийн 24.1.1–24.1.6–д заасан тохиолдолд;

/Энэ заалтад 2008 оны 2 дугаар сарын 1–ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/ гэсэн нэмэлт өөрчлөлтүүд тус тус оржээ.

### **Зүйл 16 Харгис хэрцгийгээр байцаан шийтгэхийг төр нь хориглох, хянах**

144. 2008 оны 7 сарын 1–ний хэрэг явдлын дараагаар цагдаагийн удирдлагыг уг үйл явдлын улмаас 5 хүний амь нас үрэгдсэн явдалд гэм буруутай эсэхийг шүүхээр шийдвэрлэх үед өмнө нь бид бол цэрэгжсэн байгууллага учраас тушаалаар хөдөлдөг гэсэн ойлголттой байсан боловч яг шүүхээр хэрэг шийдвэрлэх явцад бид иргэнд үйлчилдэг байгууллага болохоор цэргийн гэмт хэргээр зүйлчлэгдэхгүй гэж маргаж байсан.

145. Учир нь цагдаагийн байгууллага нь хууль сахиулах үйл ажиллагааг явуулахдаа иргэн лүүгээ хандсан зорлиго нь илүү тодорхой харагдаж байдаг хууль сахиулах чиг үүрэгтэй байгууллага болохоос цэргийн байгууллага биш гэсэн гаргалгааг гаргаж ирсэн. Гэхдээ цагдаагийн байгууллага бол цэргийн байгууллага биш боловч захиргааны байгууллага бас биш юм. Иймд ямар байгууллага байх ёстой вэ гэдэг асуудал хөндөгдсөн. Иймд бид цэргийн болон иргэний байгууллагын дунд “Хууль сахиулах байгууллага” гэсэн шинэ статус байх ёстой гэж үзсэний үндсэн дээр энэхүү шинэчлэлийг хийж байна.

146. Үндэслэл бүхий сэжиг, гэмт хэрэг, зөрчлийг бүртгэх, мөрдөн шалгах эрх бүхий цагдаа, мөрдөх болон хилийн алба, татвар, гааль зэрэг хууль сахиулах байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, ашиг ашиг сонирхлын зөрчил, авилгаас ангид нэгдсэн зарчим, журмаар хэрэгжих эрх зүйн баталгааг бүрдүүлэх шаардлагад үндэслэн Хууль сахиулах үйл ажиллагааны тухай бие даасан хуулийн төслийг боловсруулж байна.

147. Гэмт хэрэг илрүүлэх хойшлуулшгүй ажиллагаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах гүйцэтгэх ажил, нийгмийн хэв журам сахиулах, нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаанууд “хууль сахиулах үйл ажиллагаа” гэсэн ойлголтод багтаж хууль сахиулагчийн эрх зүйн байдлыг тусгайлсан хуулиар тогтооно.

Ингэснээр хүний халдашгүй эрхийг хязгаарлах, өмч хөрөнгөд халдах ажиллагаа нэг стандартаар хэрэгжих юм.

148. Ийнхүү хууль сахиулах үйл ажиллагаа нэг стандартад орсноор эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд байдаг үндэслэлгүй цагдан хорих, хөтөлж байцаах, нэр хүндийг нь гутаан доромжилж харьцах зэрэг эрүү шүүлтийн амь бөхтэй оршсоор байгаа хэлбэрүүдийг хязгаарлах боломжтой болж байгаа юм.

149. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд байгаа олон ажиллагаа, үндэслэл журмууд хууль сахиулах ажиллагаанд хамаарч байгаатай холбоотойгоор Гэмт хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл боловсруулагдаж байна.

150. Энэ хуулийн төсөлд хүнийг гэмт хэрэгт сэрдэж, баривчилсан үеэс эхлэн зөвшөөрөл олгох эрх бүхий шүүгч цагдан хорих, бусад эрхийг хязгаарлах бүхий л ажиллагааг хүний эрхийг хангаж байгаа эсэхийг харгалзаж, зөвшөөрөл олгодог байхаар тусгахаар боловсруулж байна.

151. Түүнчлэн Улсын Их Хурлаас 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан Засгийн газрын 2012–2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу зохион байгуулалттай, нууц далд аргаар үйлдэгддэг гэмт хэргийг мөрдөн шалгах “мөрдөх алба”, шүүхийн шат дахь гэрч, хохирогч, шүүгчийн аюулгүй байдлыг хамгаалах чиг үүрэгтэй “тахарын алба” зэрэг байгууллагуудыг шинээр байгуулан ажиллаж байна.

152. 2014 онд Цагдаагийн албаны тухай хууль, Тахарын албаны тухай хууль шинээр батлагдан хэрэгжиж байгаа бөгөөд мөн тус онд Авлигын эсрэг хуульд нэмэлт өөрчлөлт орсон байна.

1. Түүнчлэн дараах хууль тогтоомжоор хүнлэг бус гутаан доромжилсон хандлага залхаан цээрлүүлэлт зэрэг харгис хэрцгийгээр байцаан шийтгэхийг төр нь хориглох хянаж байх талаар заасан байна. Үүнд: Цагдаагийн албаны тухай хууль 41.1–т “Цагдаагийн албаны тухай хууль тогтоомж, өргөсөн тангаргаа зөрчсөн цагдаагийн алба хаагчид ял шийтгэл хүлээлгэхээргүй бол Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хууль, энэ хууль болон цагдаагийн албаны ёс зүйн дүрмийг баримтлан сахилгын хариуцлага ногдуулна.

2. Тахарын албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1–т “Тахарын албаны тухай хууль тогтоомж, өргөсөн тангаргаа зөрчсөн алба хаагчид ял шийтгэл хүлээлгэхээргүй бол энэ хууль болон Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Тахарын албаны алба хаагчийн ёс зүйн дүрмийг баримтлан сахилгын хариуцлага ногдуулна.

3. Авлигын эсрэг хуулийн 7.1.3 –т хориглох зүйлийг заахдаа “албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах;”

153. Хуульчийн эрх зүйн байдал буюу хууль сахиулагч болон хуульчийн үйл ажиллагааны ялгаа заагийг тодорхой болгох зорилгын хүрээнд өнгөрсөн 2012–2013 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар Шүүхийн шинэтгэлийн багц хуулиуд батлагдсан. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүхийн тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдсан бөгөөд одоо Прокурорын эрх зүйн байдлын тухай хуулийг дараагийн шатанд шинэчлэхээр төлөвлөж байна.

Монгол улсаас гадаад улстай байгуулсан Эрүүгийн болон иргэний хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай, Гэмт этгээд шилжүүлэх тухай болон Ялтан шилжүүлэх тухай гэрээний жагсаалт

№	Улсын нэр	Гэрээний нэр	Байгуулсан
1.	Унгар	Иргэн, гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа харилцан үзүүлэх тухай	1968-11-22
2.	Болгар	Иргэн, гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа харилцан үзүүлэх тухай	1968-11-27
3.	Румын	Иргэн, гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа харилцан үзүүлэх тухай	1972-11-25
4.	Чех	Иргэн, гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа харилцан үзүүлэх болон эрх зүйн харилцааны тухай	1976-10-15
5.	Словак	Иргэн, гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа харилцан үзүүлэх болон эрх зүйн харилцааны тухай	1976-10-15
6.	Ардчилсан Солонгос	Иргэн, гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа харилцан үзүүлэх тухай	1988-10-29
7.	Куба	Иргэн, гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа үзүүлэх тухай	1989-8-16
8.	Хятад	Иргэн, гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа харилцан үзүүлэх тухай	1989-8-31
		Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай	1997-8-19
		Ялтан шилжүүлэх тухай	2011-06-16
9.	Франц	Иргэний хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, иргэний хэргийн талаархи шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай конвенц	1992-2-27
10.	Казакстан	Иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа харилцан үзүүлэх тухай	1993-10-22
		Гэмт хэрэг үйлдэгсдийг эрүүгийн хариуцлагад татах буюу таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэхээр шилжүүлэн өгөх тухай	1993-10-20
11.	Польш	Иргэн, гэр бүл, хөдөлмөр, эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх болон эрх зүйн харилцааны тухай	1998-10-19
12.	Орос	Эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэний ба эрүүгийн хэргийн талаархи эрх зүйн харилцааны тухай	1999-4-20



**ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР БҮЮУ  
ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦ**

<b>№</b>	<b>Улсын нэр</b>	<b>Гэрээний нэр</b>	<b>Байгуулсан</b>
13.	Солонгос	Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай	1999-5-31
		Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай	1999-5-31
		Ялтан шилжүүлэх тухай гэрээ	2008-5-29
		Иргэний болон худалдааны хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай	2008-10-15
14.	Украин	Иргэн, гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа харилцан үзүүлэх тухай	1995-6-27
15.	Вьетнам	Иргэн, гэр бүлийн болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай	2000-4-17
16.	Киргиз	Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай	1999-12-4
17.	Турк	Иргэн, аж ахуйн болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай	2000-5-2
18.	Энэтхэг	Иргэн, аж ахуйн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай	2001-1-3
		Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай	
		Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай	
19.	Канад	Ялтан шилжүүлэн өгөх тухай	2004-10-23

ДОЛООДУГААР БҮЛЭГ

Хавсралт 2

Монгол улсаас гадаад улстай байгуулсан иргэн, эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх болон гэмт этгээдийг шилжүүлэн өгөх, ялтан шилжүүлэх тухай гэрээ

Зохицуулсан харилцаа	Гэрээний тоо	Гэрээнд заасан Төв байгууллага / гэрээний тоо	
1 Иргэний хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх	16	Хууль зүйн яам	6
		Улсын дээд шүүх	10
		Нотариатын байгууллага	3
2 Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх	16	Хууль зүйн яам	4
		Улсын ерөнхий прокурорын газар	12
3 Гэмт этгээд шилжүүлэх	15	Хууль зүйн яам	4
		Улсын ерөнхий прокурорын газар	11
		Цагдаагийн ерөнхий газар	1
4 Ялтан шилжүүлэх	7	Хууль зүйн яам	5
		Улсын ерөнхий прокурорын газар	2

Хавсралт 3

Ялтан шилжүүлсэн талаарх судалгаа

№	Огноо	Улсын нэр	Хүний тоо	Тайлбар
1	2009	Казакстан	2	Шилжүүлж авсан
		БНХАУ	1	Шилжүүлж авсан
		Чех	1	/УДШ–д харьяалал тогтоолгох санал тавьсан / шийдвэрлэгдээгүй
2	2010	БНХАУ–ын ӨМӨЗО	1	/УДШ–д харьяалал тогтоолгох санал тавьсан / шийдвэрлэгдээгүй
		ОХУ	1	Шилжүүлж авсан
3	2011	Казакстан	3	/УДШ–д харьяалал тогтоолгох санал тавьсан / шийдвэрлэгдээгүй
		Хятад	1	/Хятад улсаас иргэнээ шилжүүлэн авах хүсэлт ирүүлсэн/ шийдвэрлэгдээгүй
		Солонгос	1	Шилжүүлж авсан

**ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР БҮЮУ  
ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦ**

№	Огноо	Улсын нэр	Хүний тоо	Тайлбар
4	2012	БНХАУ	2	/УДШ–д харьяалал тогтоолгох санал тавьсан / шийдвэрлэгдээгүй
		Солонгос	2	
		БНХАУ	3	
5	2013	Казакстан	2	Санал тавьсан
		Хонг Конг	1	
		Чех	1	

Хавсралт 4

Нийт цагдан хоригдсон хүний тоо  
/2007–2014 оны эхний хагас жил/

	2007 он	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 оны эхний хагас жилд
эр	1592	1674	1324	1401	1306	1129	1099	1192
эм	106	141	84	97	100	80	79	75
эр хүү	72	49	53	55	50	25	38	29
эм хүү	1	5	2	2	2		1	1
НИЙТ	1771	1869	1463	1555	1458	1234	1217	1297

Шалгаж байгаа болон, шийдвэрлэсэн эрүүгийн хэрэгт холбогдон шалгагдсан холбогдогч нарын тоон мэдээлэл

№	Гүйцэтгэл 2007 он 2008 он	Үзүүлэлт								
		2007 он	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 оны эхний хагас жил	
1.	Нийт шалгасан эрүүгийн хэрэг	85	193	180	132	142	164	187	162	
	Яллах дүгнэлтээр	16	60	51	41	43	33	43	44	
	Хэрэгсэхгүй болгох	12	37	37	40	35	33	41	21	
2.	Үүнээс Харьяаллын дагуу шилжүүлсэн	8	37	39	20	27	25	30	16	
		Эрүүгийн хэрэг нэгтгэсэн	4	13	22	10	7	24	21	6
		Түдгэлзүүлсэн	3	11	6	6	3	2	13	8
		Ажиллагаанд	44	35	25	15	27	47	39	67
	Хэргийн холбогдогч	170	421	407	340	313	293	400	426	
3.	Үүнээс Гадаадын иргэн	2.9%	1.4%	3%	2%	1%	0.3%	-	-	
	Цагдан хорих ТСАХ авагдсан хүн	9	25	9	7	6	22	66	17	
4.	Үүнээс Гадаадын иргэн					6				
5.	Улсын хилээр нэвтрэх эрхийг түр түдгэлзүүлсэн гадаад улсын иргэн								20	

Тайлбар: Шалгагдсан эрүүгийн хэрэг, гомдол мэдээллийн тоон мэдээ нь хэрэг, холбогдогчийн тоо давхардсан байдлаар гарч байгаа болно.

Улсын ерөнхий прокурорын дэргэдэх  
Мөрдөн байцаах алба /хуучнаар/-ны 2007–2013 оны  
мөрдөн байцаалтын ажлын тоон үзүүлэлт

1. Нийт шалгасан гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн тоо

	2007 он	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он
Эрүүгийн хэрэг үүсгэсэн	221	169	171	132	183	149	145
Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасан	288	275	240	283	344	310	558
Харьяаллын дагуу шилжүүлсэн	101	70	107	78	235	104	78
Нийт	610	514	518	493	762	563	781

2. Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн төрөл

	2007 он	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он
Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг	115	90	136	129	240	209	323
Өмчийн эсрэг гэмт хэрэг	74	45	38	47	48	30	35
Албан тушаалын эсрэг гэмт хэрэг	69	17	25	39	96	68	77
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	12	18	17	14	25	8	10
Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	272	261	223	175	223	191	200
Тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөний аюулгүй байдал, албан журмын эсрэг гэмт хэрэг	50	68	29	65	93	62	88
Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	6	3	31	3	4	6	4
Бусад төрлийн гэмт хэрэг	16	15	27	30	23	9	29
нийт	614	517	526	502	752	583	766

ДОЛООДУГААР БҮЛЭГ

3. Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн холбогдогчийн судалгаа

	2007 он	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он
Шүүгч	20	13	17	18	28	25	33
Прокурор	17	3	11	14	48	16	44
Мөрдөн байцаагч	100	76	94	113	183	158	230
Хэрэг бүртгэгч	79	44	21	33	40	38	35
Цагдаагийн байгууллагын ажилтан	392	369	369	316	449	302	422
Тагнуулын байгууллагын ажилтан	3	12	14	8	19	9	13
Энгийн хүн	3					15	
нийт	614	517	526	502	767	563	777

4. Эрүүдэн шүүхийн чиглэлээр шалгасан гомдол мэдээлэл, эрүүгийн хэргийн судалгаа

он	ШТАЭГХ-ийн шалгасан гомдол	Үүнээс: Эрүүдэн шүүхийн чиглэлээр шалгасан гомдол	Шийдвэр гаргасан үндэслэл				Эрүүдэн шүүхийн чиглэлээр шалгасан эрүүгийн хэрэг			
			Эрүүгийн хэрэг үүсгэсэн	Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан	Харьяаллын дагуу шилжүүлсэн	Нийт хэрэг	Яллах дүгнэлт үйлдүүлэх санал	Хэрэг сэхгүй болгох санал	Харьяаллын дагуу шилжүүлэх санал	Түдгэлзүүлэх санал
2007	115	40	8	32		8	6	2		
2008	90	19	2	17		5	4		1	
2009	136	50	6	38	6	7	3	1	1	2
2010	129	22	2	20		2	2			
2011	240	77	7	63	7	10	8		1	1
2012	209	44	3	33	8	3	2	1		
2013	232	19	7	10	2	7	7			
Нийт	1151	271	35	213	23	42	32	4	3	3

1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан эрүүгийн хэргийн шийдвэрлэлтийн

**ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР БҮЮУ  
ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦ**

судалгаа

	2007 он	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он
Яллаха дүгнэлт үйлдүүлэх санал	110	112	110	78	111	92	80
Хэрэгсэхгүй болгох санал	76	87	74	63	85	66	79
Харьяаллын дагуу шилжүүлсэн, өөр дугаартай хэрэгт нэгтгэх, түдгэлзүүлэх санал	60	49	50	54	86	52	53
<b>НИЙТ</b>	<b>246</b>	<b>248</b>	<b>234</b>	<b>195</b>	<b>282</b>	<b>210</b>	<b>212</b>

**2. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэргийн төрөл**

	2007 он	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он
Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг	17	12	24	8	38	22	26
Өмчийн эсрэг гэмт хэрэг	37	33	32	30	31	23	23
Албан тушаалын эсрэг гэмт хэрэг	22	3	5	14	19	18	14
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	0	0	28	20	34	9	6
Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	145	160	135	98	120	166	113
Тээврийн хэрэгсэлийн хөдөлгөний аюулгүй байдал, албан журмын эсрэг гэмт хэрэг	22	26	21	24	39	17	21
Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	2	2	2	5	8	-	-
Цэргийн гэмт хэрэг	0	0	0	0	1	0	0
Бусад төрлийн гэмт хэрэг	23	29	2	11	12	6	9
<b>НИЙТ</b>	<b>268</b>	<b>263</b>	<b>249</b>	<b>210</b>	<b>302</b>	<b>261</b>	<b>212</b>

ДОЛООДУГААР БҮЛЭГ

3. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан гэмт хэргийн холбогдогчийн судалгаа


	2007 он	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он
Шүүгч	9	2	2	3	5	5	4
Прокурор	9	5	3	2	4	5	3
Мөрдөн байцаагч	15	23	20	9	31	25	23
Хэрэг бүртгэгч	26	18	12	20	20	19	11
Цагдаагийн байгууллагын ажилтан	204	238	208	155	204	147	137
Тагнуулын байгууллагын ажилтан	3	4	8	5	15	6	9
Энгийн хүн	83	79	126	135	124	66	72
нийт	349	369	379	329	403	273	259

Хавсралт 7




Хавсралт 8





Хавсралт 9

Үйлчлүүлэгчийн өргөдлийг улсын өмгөөлөгч хаанаас хүлээн авсан талаарх мэдээлэл



МОНГОЛ УЛС ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ, ХАМГААЛАХААР ГАРЫН ҮСЭГ ЗУРСАН БОЛОН  
НЭГДЭН ОРСОН ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

1. Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенц. (1967.04.05)
2. Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц. (1969.09.05)
3. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт. (1976.01.03)
4. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протокол. (2013.05.05)
5. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт. (1976.03.23)
6. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протокол. (1991.07.16)
7. Дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа үл хэрэглэх тухай конвенц. (1971.11.11)
8. Апартеидын гэмт хэргийг таслан зогсоох, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай олон улсын конвенц. (1976.07.18)
9. Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц. (1981.09.03)
10. Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт оруулсан нэмэлт өөрчлөлт. (1997.12.19)
11. Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн нэмэлт протокол. (2002.06.28)
12. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц. (2002.02.23)
13. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протокол. (2013.09.24)
14. Спортод апартеид бодлого явуулахын эсрэг олон улсын конвенц. (1988.04.03)
15. Хүүхдийн эрхийн тухай конвенц. (1990.09.02)
16. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 43 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт оруулсан нэмэлт өөрчлөлт. (2002.11.18)
17. Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт өөрчлөлт. (2004.11.06)

18. Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт өөрчлөлт. (2003.07.27)
19. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн Мэдээлэл хүргүүлэх журмын тухай нэмэлт протокол. (2013.10.04)
20. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын Цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт хоёрдугаар протокол. (2012.06.13)
21. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц. (2009.06.13)
22. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн нэмэлт протокол. (2009.06.13)
23. Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенц. (2007.02.06)

**7.4 ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ХОЁРДУГААР ИЛТГЭЛИЙГ ХЭЛЭЛЦЭЭД НҮБ-ЫН ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН ЭСРЭГ ХОРООНООС МОНГОЛ УЛСАД ӨГСӨН ЗӨВЛӨМЖ (2016 ОН)**

1. 2016 оны 8 дугаар сарын 2, 3-ны өдөр Монгол Улсын 2 дахь удаагийн илтгэлийг (CAT/C/MNG/2) Эрүүдэн шүүхийн эсрэг хороо нь 1443, 1445 дах хуралдаанаар хэлэлцээд 2016 оны 8 дугаар сарын 9-ний өдрийн 1453 дах хуралдаанаар дараах зөвлөмжийг баталлаа.

**А.Оршил**

2. Оролцогч улс нь хялбаршуулсан журмын дагуу илтгэлээ явуулсанд хороо талархаж байна. Мөн оролцогч улсын төлөөлөгчидтэй өрнүүлсэн хэлэлцүүлэг, аман хариултуудад талархаж байна.

**В.Эерэг тал**

3. Оролцогч улс дараах олон улсын гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурсан болон соёрхон баталсанд Хорооны зүгээс талархаж байна. Үүнд:

- (a) “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протокол”-ыг 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдөр соёрхон баталсан;
- (b) “Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенц”-ийг 2014 оны 10 дугаар сарын 9-ний өдөр соёрхон баталсан;
- (c) “Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пактын Цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт 2 дугаар протокол”-ыг 2012 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр соёрхон баталсан.

4. Хороо нь конвенцид хамаарах асуудлаар өөрийн хууль тогтоомжийг шинэчлэх талаар хийгдсэн өргөн цар хүрээтэй санаачлагыг талархан хүлээн авч байна. Үүнд:

- (a) “Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль”-ийг 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр батлаж, түүнийг хэрэгжүүлэх Хүн худалдаалахтай тэмцэх болон урьдчилан сэргийлэх дэд хороог байгуулсан;
- (b) 2013 онд батлагдсан Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль;
- (c) 2013 оны 7 дугаар сарын 5-ны өдөр батлагдсан Цагдаагийн албаны тухай хуулийн 40.5-д зааснаар, Хүний эрхийн Үндэсний Комисс бүрэн эрхийнхээ хүрээнд цагдаагийн алба, албан хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавина;

- (d) 2013 онд батлагдсан Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль;
- (e) 2015 онд батлагдсан Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хууль;
- (f) 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн Эрүүгийн хуулийн шинэчлэсэн найруулгад эрүүдэн шүүх, цаазаар авах ялыг халах, гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцох мөн ялгаварлан гадуурхах, үзэн ядах зэрэг нэр томьёог оруулсан;
- (g) 2016 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулинд Эрүү шүүлт тулгаж, бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий харьцаж мэдүүлэг авсан нь тогтоогдвол авсан мэдүүлгийг энэ хуульд заасан журмаар нотлох баримтаар тооцохгүй гэж шинэчлэн найруулсан,

5. Хороо нь оролцогч улсуудын конвенцийг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөр болон захиргааны арга хэмжээг өөрчлөх санаачлагыг сайшаан хүлээн авсан. Үүнд:

- (a) 2010 оноос хойш Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан цаазаар авах ялыг түдгэлзүүлсэн бүх хоригийг хэрэгжүүлсэн байдал;
- (b) 2011 оноос хойш Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт;
- (c) 2011 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 214 тоот тушаалаар батлагдсан “Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих прокурорын хяналтын заавар”-ын дагуу хариуцсан прокурор нь цагдан хоригдсон, ял эдэлж байгаа хүмүүсийн хоригдож буй нөхцөлийг шалгах, тэдгээрээс ирүүлсэн гомдол хүсэлтийг шалгаж зөрчигдсөн эрхийг сэргээх;
- (d) 2013 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/14 тоот тушаалаар батлагдсан “Цагдан хорихтой холбогдсон зарим ажиллагааг зохицуулах тухай журам”-ын дагуу цагдан хоригдох таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан яллагдагчийн эрхийг хангах, цагдан хорих санал гаргах эрх бүхий субъектийн шуурхай байх явдлыг хангах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хүн, түүний ар гэр, өмгөөлөгчид энэ талаар 24 цагийн дотор мэдэгдэж байх;
- (e) Монгол Улсын Засгийн газрын 2012–2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт шүүхээс гадуур хүний эрхийг хязгаарлах үе шатыг хязгаарлах арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр тусгасан байна;
- (f) Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн дагуу 2015–2020 оны Үндэсний хөтөлбөрийг боловсруулах;
- (g) Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссоос №.3/207 болон №. 3/1788 дугаар зөвлөмжүүдийг бүх цагдаагийн албан хаагчдад болон шоронгийн харгалзагч нарт эрүү шүүлт болоод зүй бусаар харьцахаас урьдчилан сэргийлэх зорилгоор танилцуулах;
- (h) Бүх хорих төвүүдэд хүний эрхийн талаарх ханын тусгай самбаруудыг байрлуулсан явдал юм.

### **С.Анхаарал татаж буй гол асуудлууд ба зөвлөмж**

#### **Өмнөх илтгэлээс үлдсэн асуудлууд**

6. Хороо нь 9, 11, 16 болон 19 дүгээр заалтад буй асуудлуудын дагуу (a) эрүүдэн шүүсэн үйлдэл гаргагчид ял шийтгэл завших; (b) эрүүдэн шүүсэн гэх баримт нотолгоо болон санал гомдол; (c) цагдан хорих нөхцөл; (d) цаазаар авах ялтай ялтангууд болон цаазаар авах ял зэрэг мэдээллийг хавсаргаагүй байгаад харамсаж байна.

#### **Шинэчилсэн хууль тогтоомжийг хүчин төгөлдөр болгох нь**

7. УИХ-аас 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр “Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга” болон 2016 оны 5 дугаар сарын 13-ны өдөр “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай шинэчилсэн найруулга”-ыг баталсныг Хороо сайшаан хүлээн авсан хэдий ч, эдгээр хуулийг хүчин төгөлдөр болгохыг хойшлуулж болзошгүй талаархи мэдээлэлд санаа зовниж байна (2 дугаар зүйл).

8. Шинэчилсэн хууль тогтоомж хүчин төгөлдөр болоход саад болохгүй гэдгийг баталгаажуулахын тулд оролцогч улс хүчин чармайлт гаргах нь зүйтэй.

#### **Эрүүдэн шүүх хэлбэрүүд болоод түүнд оногдуулах шийтгэлүүд**

9. Хороо нь Эрүүгийн шинэ хуульд эрүүдэн шүүх гэдгийг тодорхойлсонд сайшаасан боловч тус тодорхойлолт нь конвенцийн 1 дүгээр зүйлд заасан “эрүү шүүлт гэж ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийн бие махбодь, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдэл” гэснийг бүрэн агуулаагүй байна. Нэмж хэлэхэд эрүүдэн шүүхийн шийтгэлийг торгохоос эхлээд тав хүртэл жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэнэ гэж заасан нь гэмт хэргийн хүнд хөнгөн байдлаас үл хамаарч байна. (1, 2, 4 дүгээр зүйл).

10. Оролцогч улс нь:

- (a) Конвенцийн 1 дүгээр зүйлийн бүх элементүүдийг агуулсан эрүүдэн шүүх тодорхойлолтыг батлах. Үүнд: эрүү шүүлт тулгах сэдэл эсхүл шалтгаан, гутаан доромжлох, шахалт үзүүлэх шалтгаан зэрэг нь гуравдагч этгээдэд ч хамааралтай байхаар зааж оруулсан байх;
- (b) Эрүү шүүлт тулгах үйлдэл нь эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцож энэхүү конвенцийн 4.2-т зааснаар шийтгэл ноогдуулахыг баталгаажуулах;
- (c) Эрүү шүүлтийн гэмт хэргийг хязгаарласан хууль байхгүйг баталгаажуулах.

#### **Эрх зүйн үндсэн хамгаалалт**

11. Хороо нь хууль тогтоомжид гарсан сүүлийн үеийн өөрчлөлтийг анхааралдаа авч, тайлангийн дараах зүйлүүдэд санаа зовниж байна. Үүнд:

- (a) Хууль ёсны баривчлах зөвшөөрөлгүй баривчлагдсан хүмүүсийн тоо их байна;
- (b) Ийм хэмжээний эрх нь хязгаарлагдаж байгаа хүмүүс баривчлагдмагцаа өмгөөлөгчийн туслалцаа авах боломжгүй, мөн тодорхой тооны өмгөөлөгчид мөрдөн байцаалтад биеэр оролцож чаддаггүйд;

- (c) Хоригдож буй хүмүүст тэдний эрх, ялангуяа өмгөөлөгчтэй байх, шүүхэд гомдол гаргах, гэр бүлийнхэнтэйгээ уулзах эрхийнх нь талаар мэдээлдэггүй;
- (d) Монголын Хуульчдын Холбоо болон Монголын Өмгөөлөгчдийн холбоонд албан ёсны бичгээр мэдэгдсэний үндсэн дээр хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй авдаг тул албадан саатуулагдсан этгээд анхнаасаа хууль зүйн туслалцаа авах боломжгүй байдаг;
- (e) Хороонд хэд хэдэн хэрэг дээр мөрдөн байцаагч, прокурор нар цагдан хоригдож буй хүмүүсийн гэр бүлийн гишүүдтэй нь үйлдсэн гэмт хэргээ хүлээх нөхцлөөр тэдэнтэй уулзах эрхийг олгосон гэсэн мэдээлэл ирсэн;
- (f) Цагдан хорихдоо тэдгээр хүмүүсийг гэр бүлээс нь хол хорьдог нь гэр бүлтэйгээ уулзахад хүндрэл үүсдэг. (2 болон 16 дугаар зүйл).

12. Цагдан хоригдож эхэлсэн анхны өдрөөс эхлэн цагдан хоригдогчийг эрх зүйн бүхий л хамгаалалтаар хангах, Шүүхийн шийдвэргүй баривчлах зэрэг наад захын олон улсын стандартын дагуу эрх хязгаарлахгүй тал дээр Орлоцогч улс түргэн шуурхай, үр нөлөөтэй арга хэмжээ авах хэрэгтэй. Саатуулагдсан хүмүүсийн хамгаалалтанд дараах зүйл багтана:

- (a) Тэднийг ямар хэрэгт саатуулсан болон хуулийн хүрээнд эдлэх эрхийг амаар болон бичгээр мэдээлсэн байх;
- (b) Эрх чөлөөг хязгаарласан эхэн үеэс өмгөөлөгчийг биеэр ирүүлж мөрдөн байцаалтын үед ярилцлага хийлгэх, төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлэх явдлыг шуурхай хангах;
- (c) Гэр бүлийн гишүүн эсвэл саатуулагдсан этгээдийн сонгосон хүнд цагдан хоригдсон тухай даруй мэдэгдэх;
- (d) Гэр бүлийн гишүүнтэй хийх уулзалтыг ямар нэг нөхцөл заалгүйгээр уулзуулах;
- (e) Хоригдлуудтай уулзах боломжийг хангах үүднээс гэр бүлээс нь хэт хол биш боломжийн зайд байрлуулах.

### **Цагдан хорих хугацаа**

13. Хороо нь цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээнээс гадна өргөн хүрээний тухайлбал, хорио цээрийн арга хэмжээ авах, хуулиар тогтоосон хугацаанаас илүү хугацаагаар хорих зэрэг явдал илтгэлд байгаад анхаарлаа хандуулж байна. Түүнчлэн цагдан хоригдож байгаа хүмүүсийн 12-оос дээш хувь нь 12 сараас илүү хугацаагаар хоригдож байсан бол 3-аас дээш хувь нь 30 сараас илүү хугацаагаар саатуулагдсан байдаг. Хороо нь цагдан хоригдсон тус хугацаанууд шүүхээр шийдэгдсэн хорих нийт хугацаанд тооцогдохгүй байгаад зовниж байна. (2 болон 11 дүгээр зүйл)

14. Орлоцогч улс нь:

- (a) Хууль тогтоомжид цагдан хорих хугацааг багасгах чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулах, ингэхдээ зайлшгүй тохиолдолд хязгаарлагдмал хугацаагаар хэрэглэх, хууль тогтоомжийн үндсэн суурь болон байцаан шийтгэх ажиллагааны үндсэн баталгаа болгохын тулд шүүхийн хяналтанд байхаар зохицуулах;

- (b) Хэн ч хуулинд зааснаас илүү хугацаагаар цагдан хорих газар хоригдохгүй ба энэхүү хоригдсон хугацааг тухайн гэмт үйлдэлд нь олгосон ял болох шоронд өнгөрүүлэх хугацаанд тооцон оруулах;
- (c) Цагдан хорих ажиллагааг НҮБ-ын урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах стандарт журмын дагуу урьдчилан сэргийлэх гэхийн оронд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах гэж солих (Токиогийн дүрэм);
- (d) Шударга бусаар саатуулагдсан хохирогчдыг цагаатгах болон нөхөн олговрыг олгодог байх.

**Эрүүдэн шүүх үйлдэл гаргагчид ял завшиж байна.**

15. Хороо нь дараах зүйлийг авч үзнэ:

- (a) 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр Прокурорын тухай хуулийн 10, 45 дугаар зүйлүүдэд нэмэлт, өөрчлөлт орсноор Мөрдөн байцаах албыг татан буулгахад хүргэсэн. Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албаны орон тоо, чиг үүргийн зарим хэсэг нь Авлигатай тэмцэх газарт, зарим чиг үүрэг нь Цагдаагийн байгууллагын мөрдөн байцаах албанд шилжүүлсэн. Энэ нь ашиг сонирхлын зөрчил, үр дүнгүй мөрдөн байцаалт болон эрүүгийн хэрэг үүсгэхэд хүргэж болзошгүй. ЦЕГ-ын Мөрдөн байцаах албаны хийсэн мөрдөн байцаалтын үр дүнгийн талаарх мэдээлэл хангалтгүй байх, мөн АТГ нь эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйл заасан гэмт хэргийг мөрдөн шалгах харьяалалгүй байх зэрэг нөхцөл байдал үүсч болзошгүй;
- (b) Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу эрүү шүүлт тулгасан цагдаагийн албан хаагчийг харьяа цагдаагийн мөрдөн байцаах хэлтэс хариуцна;
- (c) Цагдан хорих байруудад байх байцаалтын бүх өрөөнүүд нь хяналтын камер болон дуу бичлэгийн төхөөрөмжөөр бүрэн тоноглогдоогүй бөгөөд зарим тохиолдолд хэрэгтэн нь бичлэгийн төлбөрийг өөрөө хариуцна. (2,12,13,15,16 дугаар зүйлүүд)

16. Хороо нь өмнөх зөвлөмжөө дахин давтаад (CAT/C/MNG/CO/1, 9 дүгээр зүйлийг харна уу) Орлоцогч улс нь:

- (a) Эрүү шүүлт тулгах, төрийн албан хаагчид түүний дотор цагдаагийн байгууллагад эрүүдэн шүүх болон зүй бусаар харьцсан тухай мэдээллийг шуурхай, үр дүнтэй бөгөөд хараат бус бие даасан арга барилаар шалгаж, мөрдөн байцаагч болон сэжигтэн этгээдүүдийн хоорондын шаталсан болон зохион байгуулалтын хамаарал, холбоогүй байх;
- (b) Эрүү шүүлт тулгах болон хэрцгий харьцах явдалтай холбогдсон мөрдөн байцаалтанд орсон бүх хүмүүсийг үүргээс нь түр чөлөөлөх бөгөөд мөрдөн байцаалтын туршид гэм буруугүйд тооцох зарчмыг сахиулахыг баталгаажуулах;
- (c) Улсын бүхий л хэсэгт байх цагдан хорих байрны байцаалтын бүх өрөөнүүдэд байцаалт явуулахдаа видео болон аудио бичлэг хийх тоног төхөөрөмжтэй байлгах; видео бичлэгийг эрүү шүүлт болон бусад стандарт зөрчсөн тохиолдлуудыг илрүүлэх, шалгах зорилгоор ашиглах; шүүгдэгч болон тэдний



өмгөөлөгч нарт энэ бичлэгүүд нь нээлттэй байх; шүүгдэгчид ямар ч үнэ төлбөргүйгээр гаргаж өгөх; мөн тэдгээрийг шүүхэд нотлох баримт болгох ашиглах;

- (d) 2016 оны 7 дугаар сард оролцогч улсаас өгсөн мэдээлэлд дурьдсанчлан ЦЕГ–ын Мөрдөн байцаах албанд шалгагдаж буй эрүү шүүлт тулгасан гэх гурван гомдлын шийдвэрийн талаар Хороонд мэдээлэх.

**Гомдол, түүнийг шуурхай, хараат бус, үр нөлөөтэй мөрдөн шалгах нь**

17. Хорооны зүгээс өмнөх дүгнэлтийг эргэн сануулж (CAT/C/MNG/CO/1, 11 зүйлийг харна уу), 2008 оны 7 дугаар сарын 1–ний өдөр болсон үйл явдалд арга хэмжээ авахгүй байгаад санаа зовниж байна. Эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулах эрх мэдлийг шилжүүлсэн нь эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийн гомдлын тоог бууруулж болох юм (2, 12 болон 13 дугаар зүйлүүд).

18. Хорооны зүгээс өөрийн зөвлөмжийг дахин давтахад (CAT/C/MNG/CO/1, 11–дүгээр зүйлийг харна уу) Оролцогч улс нь:

- (a) Эрүүдэн шүүх болон зүй бусаар харьцахтай холбоотой гомдлыг хүлээн авч шуурхай, хянан шийдвэрлэх хараат бус, үр дүнтэй механизмыг амьдралд нэвтрүүлэх шаардлагатай байна;
- (b) Ял завших байдалд шүүмжлэлтэй хандаж, эрүүдэн шүүх, зүй бусаар хандах аливаа үйлдэлд буруутай нь тогтоогдсон 2008 оны 7 дугаар сарын 1–ний өдөр болсон үйл явдлын хамааралтай этгээдийг цаг алдалгүй шийтгэх;
- (c) Конвенцийн 13 дугаар зүйлд заасны дагуу гомдол гаргагч, өмгөөлөгч, гэрчийг айлган сүрдүүлэх, тэдэнтэй зүй бусаар харьцахаас хамгаалах арга хэмжээ авах шаардлагатай.

**Хорих байрны нөхцөл**

19. Хороо тэмдэглэхдээ онцгой дэглэмтэй хорих ялыг халж нээлттэй болон хаалттай дэглэмээр шоронд хоригдлуудыг хорих болсноор даац нь хэтэрсэн их хүнтэй, амьдрах орчны нөхцөл тааруу баривчлах байр ялангуяа Дэнжийн мянган цагдан хорих төвийн нөхцөл байдалд санаа зовниж байна. Түүнчлэн сэтгэцийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нийгмийн халамжийн төвүүдэд хяналт тавьдаг хяналтын механизм байхгүй байна.

20. Хороо нь өмнөх зөвлөмжөө дахин давтаж (CAT/C/MNG/CO/1, 16 дугаар зүйлийг харна уу) шоронгийн нөхцөл байдал нь хүний эрхийн олон улсын холбогдох стандартуудад нийцэж байгаа эсэх НҮБ–ын Хоригдлуудтай харьцах наад захын стандарт журам (Нельсон Манделагийн Дүрэм)–ыг баталгаажуулж, шаардлагатай алхмуудыг хийхийг Оролцогч улсад уриалж байна. Ялангуяа,

- (a) Хэт их ачааллыг багасгах, амьдрах орчинг сайжруулах, ялангуяа Дэнжийн мянган цагдан хорих байранд хангалттай нөөцийг хуваарилах мөн 2016 онд баригдсан 4 хорих төвийн талаар шинэчилсэн мэдээлэл өгөх;
- (b) Токиогийн дүрмийн дагуу хорихоос бусад төрлийн болон арга хэмжээ авах талаар авч үзэх;
- (c) Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос эрх чөлөө нь зөрчигдөж буй

бүх газар, тухайлбал сэтгэцийн болон нийгмийн халамжийн төвүүдэд бие даасан, тогтмол хяналт тавьж, урьдчилан сэргийлэх хараат бус механизмыг бэхжүүлэх, түүнчлэн хоригдож байгаа хоригдлуудын гомдлыг шийдвэрлэх боломжийг тэдэнд олгож, гомдлын мөрөөр үр дүнтэй арга хэмжээ авах.

### **Цаазаар авах ялаар шийтгэгдсэн ялтан**

21. Оролцогч улс 2016 оны 9 дүгээр сарын 1–ний өдөр хүчин төгөлдөр болох Эрүүгийн хуулиар цаазаар авах ялыг хүчингүй болгож байгаа бөгөөд Хорооны зүгээс оролцогч улсын анхны тайланг хэлэлцэх үед цаазаар авах ялаар шийтгүүлсэн хоригдлуудын одоогийн байдал хийгээд 2015 онд цаазаар авах ялаар шийтгүүлсэн хоёр хүний байдалд санаа зовниж байна. (2,11,16 дугаар зүйлүүд)

22. Хороо нь өмнөх зөвлөмжөө дахин давтахад (CAT/C/MNG/CO/1, 19–р зүйлийг харна уу), Оролцогч улс нь:

- (a) Цаазаар авах ялтай хоригдлуудын ялыг хорих ял болгож хөнгөрүүлэх мөн урьд өмнө нь цаазаар авах ялтай байсан хоригдлууд бусад хоригдлуудын нэгэн ижил дэглэмд ял эдлүүлэх;
- (b) Өмнө нь цаазаар авах ялтай байсан этгээдийг Конвенциор олгосон бүх хамгаалалт, түүний дотор эрх зүйн үндсэн хамгаалалтаар хангах;
- (c) Өмнө нь цаазаар авах ялтай байсан хорих ял эдэлж байгаа хоригдлууд олон улсын жишигт нийцсэн наад захын хэрэгцээ, эрхээ эдлэх нөхцөлөөр хангах;
- (d) Хороонд Оролцогч улсаас ирүүлсэн анхны тайланд дурьдагдсан байсан цаазаар авах ялтай байсан хүмүүсийн нөхцөл, шоронгийн дэглэмийн талаар болон 2015 онд цаазаар авах ялтай байсан 2 хоригдлын талаар шинэчилсэн мэдээлэл ирүүлэх.

### **Насанд хүрээгүй этгээдийг шүүх ажиллагаа**

23. Хороо нь Оролцогч улсын төлөөлөгчидтэй хийсэн үр дүнтэй хэлэлцүүлгийн үед тэдний өгсөн хариултуудыг анхаарахын зэрэгцээ тус улсад насанд хүрээгүй хүмүүст зориулсан мэргэжлийн шүүх болон насанд хүрээгүй хүмүүсийн шүүхийн иж бүрэн тогтолцоо байхгүй явдалд санаа зовнисоор байна. Мөн цагдан хорих байранд хүүхдийг томчуудаас тусгаарлахгүй байгаад Хороо зовинож байна. (2, 10, 11 болон 16–р зүйлүүд).

24. Оролцогч улс нь:

- (a) “Насанд хүрээгүй этгээдийг шүүхэд баримтлах дүрэм журмын наад захын” стандарт (Бээжингийн дүрэм) болон НҮБ–ын Насанд хүрээгүй хүмүүсийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх удирдамж (Riyadh–ын удирдамж) зэрэг олон улсын стандарт жишигт нийцсэн насанд хүрээгүй хүмүүсийг шүүх үр дүнтэй, мэргэшсэн, сайн ажиллагаатай тогтолцоог бий болгох асуудлыг авч үзэх;
- (b) Насанд хүрээгүй хүмүүст эдлүүлэх хорих ял нь хамгийн сүүлчийн арга хэмжээ байх бөгөөд хуульд заасны дагуу болох боломжит богино хугацаанд ялыг эдлүүлэх боломжоор хангах;
- (c) Шүүгчид болон прокуроруудад зориулж насанд хүрээгүй хүмүүсийн шүүхийн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр бий болгож, хорихоос өөр төрлийн арга хэмжээ

болон хууль зөрчигч насанд хүрээгүйчүүдэд авсан хорихоос өөр төрлийн арга хэмжээний талаар эрх зүйн тогтолцоонд тусгах;

- (d) Эрх чөлөөгөө хасуулсан насанд хүрээгүй хүмүүсийг насанд хүрэгчдээс тусад нь байлгах;
- (e) Насанд хүрээгүй хоригдогсдын нөхцөл байдлыг хараат бусаар тогтмол хянах;
- (f) Баянзүрх дүүрэгт байрладаг насанд хүрээгүй хүмүүст зориулсан тусгай сургалт, боловсролын төвийн барилгын ажлыг хурдасгаж, 2017 онд дуусгах.

#### **Хүүхдийн эсрэг бие махбодийн шийтгэл**

25. Хороо нь Хүүхдийн эрхийн тухай хууль болон Хүүхэд хамгааллын тухай хууль үйлчилж эхэлсэн нь хүүхдийн бие махбодийн шийтгэлийг эрүүгийн хариуцлагад тооцох болсонд талархаж байна. Хороо нь хүүхдийн 42 хувь нь гэр бүлийн орчинд бие махбодийн болоод сэтгэл зүйн шийтгэлд өртдөг талаарх мэдээлэлд санаа зовниж байна. (16–р зүйл)

26. Орлоцогч улс нь:

- (a) Бүх нөхцөл байдалд бие махбодийн шийтгэлийг хориглохыг бүрэн хэрэгжүүлэх, хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л алхмуудыг хийх;
- (b) Бие махбодийн шийтгэлийн хор хөнөөлийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, хүчирхийлэлгүй сахилгын арга барилыг сурталчлах боловсрол олгох, хүүхдүүдийг өсгөх, асран халамжлахад чиглэсэн мэдлэгийг дээшлүүлэх ажил явуулах;
- (c) Бие махбодийн шийтгэлийн бүх мэдээлэгдсэн хэргүүдийг мөрдөн шалгаж, яллан шийтгэх.

#### **Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийлэл**

27. Хороо нь 2016 оны 9–р сарын 1–нд хүчин төгөлдөр болох Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад гэр бүлийн хүчирхийлэл, эмэгтэйчүүд болон охидын эсрэг хүчирхийллийн бусад хэлбэрүүдийг тусгаж, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийг хамгаалах дөрвөн шинэ байр байгуулсанд талархаж байна. Хороо нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл түүний дотор бэлгийн болон гэр бүлийн хүчирхийлэл, байсаар байгаад, түүнчлэн хэргүүдийг мэдээлэхгүй байх эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх статистикийн мэдээлэл дутмаг байх, гэрлэлтийн хүчинг гэмт хэрэгт тооцдоггүй зэрэгт санаа зовниж байна. (2, 12–14 болон 16–р зүйлүүд).

28. Орлоцогч улс нь:

- (a) Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга болоод Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтийн холбогдох зүйлүүдийг эрчимтэй, үр дүнтэй хэрэгжүүлэх;
- (b) Гэрлэлтийн хүчинг гэмт хэрэгт тооцохын тулд хууль тогтоомжид өөрчлөлт оруулах;
- (c) Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод зориулсан үр дүнтэй, бие даасан гомдол барагдуулах механизмыг бий болгох;

- (d) Гэр бүлийн хүчирхийлэл, түүний дотор бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх бүх мэдээллийг цагдаагийн байгууллага бүртгэдэг байх мөн гэр бүлийн хүчирхийллийн талаарх бүх гомдлыг шуурхай, шударгаар, үр дүнтэй мөрдөн шалгаж, хүчирхийлэгчид хариуцлага хүлээлгэж, шийтгэдэг байх;
- (e) Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид нь хамгаалалт, үүнд эрх хязгаарлах арга хэмжээнээс үр дүнг хүртэх, эмнэлгийн болоод хууль зүйн үйлчилгээ, ялангуяа зөвлөгөө өгөх боломжтой олон тооны найдвартай бөгөөд хангалттай санхүүжилттэй хамгаалах байраар хангах, одоо байгаа хамгаалах байруудыг сайжруулж, нөхөн сэргээх үйлчилгээний талаархи мэдээллээр хангах;
- (f) Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх, жендэрээс үүдэлтэй болон гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн эмзэг байдлын талаар цагдаагийн болон бусад хууль сахиулах байгууллагын ажилтнууд, нийгмийн ажилтан, шүүгч, прокурор, эмнэлгийн ажилтнуудад зайлшгүй шаардлагатай сургалт явуулах;
- (g) Хохирогчдын нас, яс үндэс, хохирогч хүчирхийлэгч хоорондын холбоо болон эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн ба бусад хүчирхийлэл гэрлэлтийн хүчингийн талаарх гомдлын тоо, мөрдөн байцаалт, хүчирхийлэл үйлдэгчдийн гэм буруутай нь тогтоогдсон, ял шийтгэл оногдуулсан, ял эдэлсэн байдлын талаар статистик тоо баримтыг гаргах.

**Лесби, гей, бисексуал, трансжэндэр болон интерсекс хүмүүсийн эсрэг хүчирхийлэл ба ялгаварлан гадуурхалт**

29. Хороо нь Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад янз бүрийн үндэслэлээр ялгаварлан гадуурхах, үзэн ядалт болон үзэн ядалтыг илэрхийлэхийг хориглосны үндсэн дээр эмзэг бүлгийн хүн ам, ялангуяа лесби, гей, бисексуал, трансжэндэр болон интерсекс хүмүүс хүчирхийлэлд өртдөг, тухайлбал бие махбодын халдлага болоод бусад зүй бус харьцаа түүний дотор цагдаагийн ажилтнууд байх бөгөөд ингэснээрээ хохирогчид гомдол гаргахаас татгалздаг гэдгийг анхааралдаа авч, тус гомдлууд нь цагдаагийн байгууллагад бүртгүүлээгүй эсвэл мөрдөн байцаалтад ороогүй мөн Прокурорын газраас нь хэрэгсэхгүй болгосон тухай тайланд гарсанд Хороо ихээхэн санаа зовниж байна.(2, 12, 13, 16–р зүйл).

30. Оролцогч улс нь:

- (a) Эрүүгийн хуулийн холбогдох заалтуудыг 2016 оны 9 дүгээр сарын 1–ний өдрөөс эхлэн эрчимтэй дагаж мөрдүүлэх;
- (b) Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллээс болж халдлагад өртөгсдийн гомдол, мэдээллийг “Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл”–тэй холбоотой асуудалд олон улсын хүний эрхийн эрх зүйг хэрэглэх Жогжакарта (Yogyakarta)–гийн зарчим”–д нийцүүлэн түргэн шуурхай, бүрэн гүйцэд, хараат бусаар мөрдөн шалгах бодлого, бодлогын хэрэгжилт, гомдол хянан шийдвэрлэх механизмуудыг байгуулах хэрэгтэй байна;
- (c) Лесби, гей, бисексуал, трансжэндэр болон интерсекс хүмүүстэй зүй бусаар харьцсан тэр дотроо цагдаагийн ажилтнуудын үйлдсэн гэх бүх гомдлыг шалгаж, мөрдлөг явуулж, мөн мөрдөн байцаалтын шат дуустал бүх этгээдийг нэн даруй албан үүргээс нь түдгэлзүүлсэн байх;

- (d) Эмзэг бүлгийнхний эсрэг хүчирхийлэл үйлдэгчийг (ялангуяа лесби, гей, бисексуал, трансжэндэр болон интерсекс хүмүүс) шударгаар шүүх шаардлагатай бүхий л арга хэмжээг авах;
- (e) Хохирогчид нөхөн олговор олгох буюу нөхөн сэргээх зэрэг хохирлыг нь барагдуулах.

### **Хүний наймаа**

31. Хороо нь Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль болон Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 113 дугаар зүйлийг сайшаахын зэрэгцээ Оролцогч улс нь хүн худалдаалах гэмт хэргийн өлгий газар хэвээр үлдэж байгаад ялангуяа насанд хүрээгүй хүмүүсийг албадан хөдөлмөр, хүчээр бэлгийн мөлжлөгт ашиглах, хууль сахиулах байгууллагын ажилтнуудыг оролцуулсан гэх хэргүүдэд Хороо санаа зовниж байна. Эрүүгийн хуулийн 113 болон 124 дүгээр зүйлийн хоорондох ойлгомжгүй мэдээлэл болон прокурор, цагаачлал, хууль сахиулах байгууллагын ажилтнуудад хангалтгүй сургалт явуулж, түүнчлэн хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх нэгдсэн зохицуулалт байхгүйгээс хохирогчдод үзүүлэх дэмжлэг, хамгаалалтыг бий болгоход саад учруулж байгаад Хороо санаа зовниж байна (2, 10, 12–14 болон 16–р зүйлүүд).

32. Оролцогч улс нь :

- (a) Хүн худалдаалахын эсрэг олон улсын болон дотоодын хууль тогтоомжийг чангатгах, мөн хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хангалттай хөрөнгө санхүүжилтийг хуваарилах, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх нэгдсэн тогтолцоог бий болгох;
- (b) Хүн худалдаалах гэмт хэргийг устгах мөн түүнээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ авах, тухайлбал төрийн албан хаагчид буюу хууль сахиулах, цагаачлал, прокурорын ажилтнуудад хохирогчийг хэрхэн таньж мэдэх мөн гэмт хэрэгтнийг мөрдөн шалгаж, яллах болон шийтгэл оногдуулах талаар сургалт явуулах;
- (c) Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн дагуу 2015–2020 оны үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх, ийм гэмт хэргийн шинжтэй хэргийг онцолсон урьдчилан сэргийлэх кампанит ажил явуулах;
- (d) Хүн худалдаалах гэмт хэргийг түргэн шуурхай, үр дүнтэйгээр шалгах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цагдаагийн албан хаагчид гэмт хэргийн ноцтой байдлын дагуу гэмт хэрэгтнийг яллах, шийтгэх;
- (e) Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод, ялангуяа насанд хүрээгүй хүмүүст үнэ төлбөргүй эрх зүйн туслалцаа, эмнэлгийн болон сэтгэл зүйн тусламж, нөхөн сэргээх зэрэг нөхөн олговрыг хохирогчдод олгох мөн хамгаалалтыг нэмэгдүүлэх, Хүн худалдаалах гэмт хэргийн зөрчлийг тайлагнахад туслалцаа үзүүлэх, цагдаагийн байгууллагад мэдээлэх;
- (f) Нэгдсэн Үндэстний Байгууллагын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Конвенц болон түүний протоколуудыг оролцогч улс 2008 онд соёрхон баталсны дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх үүднээс олон улсын хамтын ажиллагааг үргэлжлүүлэх; хохирогчийг эрүүдэн шүүх магадлалтай гэдэгт итгэх

- хангалттай үндэслэл байгаа бол хохирогчийг эх орон руу нь буцаахгүй байх;
- (g) Хороонд Хүн худалдаалах гэмт хэрэгтнийг хүлээлгэн өгсөн хүмүүс болон мөрдөн байцаах, яллах, шийтгэх ажиллагааны тоог нарийвчлан задалсан мэдээлэл мөн хохирогчдод нөхөн төлбөр олгосон талаарх заалтыг гаргаж өгөх.

**Хүний эрхийн үндэсний байгууллага, үндэсний урьдчилан сэргийлэх механизм**

33. Хороо нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын бүрэн эрхийг өргөтгөж, түүний дотор Конвенцийн Нэмэлт Протоколын дагуу үндэсний урьдчилан сэргийлэх механизм болгон тодорхойлсон хуулийн төслийг анхааралдаа авч, Комиссын төсөв жил бүр буурч, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөцгүй байж болзошгүй талаар санаа зовниж байна. (2 зүйл).

34. Оролцогч улс нь:

- (a) Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын шинэчилсэн хуулийн дагуу цагдаагийн байгууллага түүний ажилтнуудын үйл ажиллагаанд хяналт тавих, одоогийн эрх мэдэл, түүний дотор үндэсний урьдчилан сэргийлэх механизм болох чадавхийг бэхжүүлэхийн зэрэгцээ Конвенцийн Нэмэлт Протокол болон Эрүү шүүлтийн болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс сэргийлэх дэд хорооны урьдчилан сэргийлэх механизмын удирдамжийг бүрэн дагаж мөрдөх ёстой,
- (b) Санхүүгийн болон хүний нөөцийг хангалттай хүрэлцэхүйц байлгах, өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх бие даасан, үр дүнтэй байх зохистой бүтцийг бий болгохын тулд арга хэмжээ авах үүнд, хүний эрхийг хамгаалах, дэмжих үндэсний байгууллагуудын статустай холбоотой ойлгомжтой, ил тод, оролцооны сонголттой томилгоог албажуулах (Парисын зарчмууд).

**Дүрвэгсдийг албадан гаргахгүй байх**

35. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 46, 47 дугаар бүлэгт гадаад улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн буюу шийтгэгдсэн гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнийг шилжүүлэн өгөхөөс татгалзах үндэслэлүүдийг тусгасан боловч эрүүдэн шүүх аюул тулгарна гэж үзэх хангалттай үндэслэл байх тохиолдлыг Оролцогч улсаас байгуулсан гэмт этгээд шилжүүлэн өгөх тухай хоёр талын болон олон талт гэрээ хэлэлцээрүүдэд тусгаагүй байх ба тэдгээр гэрээнүүд нь албадан буцаахгүй байх зарчмыг хүндэтгэхгүй байгаад Хороо санаа зовниж байна. (2,3 болон 16–р зүйлүүд).

36. Оролцогч улс нь:

- (a) Конвенцийн 3 дугаар зүйлд заасан үүргээ биелүүлэхийн тулд Оролцогч улс хууль тогтоомж, шүүх, захиргааны бүхий л арга хэмжээ авах шаардлагатай байна;
- (b) Гадаадын иргэнийг албадан гаргах тухай хууль тогтоомж нь албадан гаргах шийдвэрийг шүүхэд давж заалдсан бол ажиллагааг түр хойшлуулдаг байх;
- (c) Эрүү шүүлтэд өртөх эрсдэлтэй гэдэгт итгэх хангалттай үндэслэл байгаа улс орнуудад ямар ч хүнийг албадан гаргаж, буцааж өгөх буюу шилжүүлэн өгөхийг хориглох;
- (d) Оролцогч улсаас байгуулсан хоёр талын болон олон талт гэмт этгээд шилжүүлэн өгөх тухай гэрээгээр албадан буцаахгүй байх зарчмыг хүндэтгэх;

- (е) Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенц болон протоколд нэгдэн орох талаар авч үзэх.

### **Сургалт**

37. Цагдаагийн байгууллагад хийдэг сургалтын талаар тэмдэглэхийн хажуугаар бусад төрийн албан хаагчдад Конвенцийн заалтуудын дагуу хангалттай сургалт явуулдаггүй тухайлбал, эрүүдэн шүүхийг бүрэн хориглох, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл болон хүний наймаа зэрэг багтана. Мөн цагдан хорих асуудал хариуцдаг эрүүл мэндийн бүх ажилтнуудыг “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэсэн үйлдлийг мөрдөн шалгаж, баримтжуулах гарын авлага”-аар (Истанбулын протокол) мэргэшүүлэх сургалтад хамруулах хэрэгтэй байна. (10–р зүйл).

38. Оролцогч улс нь:

- (а) Конвенц буюу ялангуяа эрүүдэн шүүхийг хориглосон заалт, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл болон хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх талаар шүүгч, прокурор, өмгөөлөгч болон хууль сахиулах байгууллагын ажилтнуудад зориулсан сургалтыг зохион байгуулах шаардлагатай;
- (b) Истанбулын Протокол нь бүх эмнэлгийн мэргэжлийн хүмүүс болон бусад албан тушаалтнуудад зориулсан сургалтын нэг чухал хэсэг болсон гэдгийг баталгаажуулах;
- (c) Эрүү шүүлтийн хэргийн тоог цөөрүүлэх тухай Конвенцийн заалтуудын талаар хууль сахиулах болон бусад албан тушаалтанд явуулж буй сургалт, боловсролын хөтөлбөрийн үр нөлөө хийгээд үр дүнг үнэлэх тодорхой аргачлал боловсруулж хэрэгжүүлэх.

### **Хохирол барагдуулах буюу нөхөн төлбөр болон нөхөн сэргээх**

39. Сэтгэл санааны хохиролд нөхөн төлбөр олгох талаар хуульд нэмэлт оруулж Эрүүгийн байцаан шийтгэх хуульд бие махбодийн болон ёс суртахууны хохирлын аль адинд нөхөн олговор олгох болсныг тэмдэглэхийн сацуу эрүү шүүлт, зүй бусаар харьцсаны улмаас хохирсон хохирогчид нөхөн сэргээх, нөхөн олговор олгох талаар тусдаа бие даасан хууль байхгүйд Хороо санаа зовниж байна. (2 ба 14–р зүйл).

40. Оролцогч улс эрүү шүүлт болон зүй бус харьцсаны улмаас хохирсон хохирогчид шударга, зохистой нөхөн олговор, нөхөн сэргээх эрхтэй болох хууль тогтоомжийг батлан гаргаж, санхүүжилтийг бий болгох. Түүнчлэн нөхөн төлбөр, нөхөн олговрын талаарх хүсэлтийн тоо, шүүхээр олгогдсон тоо, захиалсан дүн бүрийн талаарх мэдээллийг өгөх ёстой. Үүнээс гадна Оролцогч улс дээрхи төрлийн хохирогчдод гэмтлийн эмчилгээ нөхөн сэргээх бусад хэлбэр зэргийг нөхөн барагдуулах хөтөлбөрийн талаар мэдээлэл өгөх ёстой.

### **Дагаж мөрдөх**

41. Хороо нь Оролцогч улсаас суурь эрх зүйн үндсэн хамгаалалт, ял шийтгэлийг оногдуулж буй талаар зөвлөмжийн хэрэгжилтийн явцын талаар 2017 оны 8–р сарын 12–

ны өдөр мэдээлэл ирүүлэхийг хүсч байна. (12(a)-(d), 16(a). Мөн Оролцогч улсыг ирэх тайлангийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төлөвлөгөөнийхөө талаар Хороонд дүгнэлтээ ирүүлэхийг хүсч байна.

**Бусад асуудлууд**

42. Хороо зөвлөмжөө дахин давтан (CAT/C/MNG/CO/ 1, 29 дүгээр зүйлийг харна уу), Оролцогч улс нь Хүний эрхийн төлөв байдлын дагуу Конвенцийн 21, 22 дугаар зүйлд заасан хүлээн зөвшөөрсөн олон талт үе шаттай хэлэлцэн тохиролцсон тунхаглал гаргах;

43. Хороо нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн үндсэн гэрээ хэлэлцээрт нэгдэн орохыг Оролцогч улсад уриалж байна. Тухайлбал, Цагаач ажилчид, тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенц болон Бүх хүнийг хүчээр алга болгохоос хамгаалах тухай олон улсын конвенц зэрэг.

44. Оролцогч улсыг гурав дахь үе шатны илтгэлээ 2020 оны 8 дугаар сарын 12 ноос өмнө ирүүлэхийг урьж байна.



**7.5 ЭРҮҮДЭН ШҮҮХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ ХАРИУЦСАН  
ДЭД ХОРОО МОНГОЛ УЛСАД 2017 ОНЫ 09 САРЫН 11–ЭЭС 20–НЫ ӨДРҮҮДЭД  
ХИЙСЭН АЙЛЧЛАЛ: АЖИГЛАЛТ БОЛОН ОРОЛЦОГЧ УЛСАД ХАНДСАН  
ЗӨВЛӨМЖҮҮД  
(Дэд хорооны тайлан<sup>4</sup>)**

**I. Танилцуулга**

1. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн Нэмэлт протоколын хүрээнд олгогдсон эрхийн дагуу (ЭШУСДХ) 2017 оны 09 сарын 11–ээс 20–ны өдрүүдэд айлчлал хийсэн.

2. Айлчлалд оролцсон дэд гишүүд: Малколм Д.Эванс (бүрэлдэхүүний ахлагч), Сатякхоошун Гупт Дома, Мария Дэфинис–Гояанофик, Коста Митровик, Маргарет Остэрфэлд, Виктор Захария. НҮБ–ын Хүний эрхийн дээд комиссарын газрын ажлын албанаас хүний эрхийн асуудал хариуцсан гурван ажилтан, НҮБ–ын аюлгүйн асуудал хариуцсан хоёр ажилтан, дөрвөн орчуулагч тус бүрэлдэхүүнд туслалцаа үзүүлэн ажилласан болно.

3. Дэд хорооныхон айлчлалынхаа хүрээнд цагдаагийн хэлтсүүд, хорих ангиуд, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлдэг, эрүүл мэндийн, сэтгэцийн, цэргийн институци дахь саатуулан хорих байруудтай газар дээр нь очиж танилцсан болно (Хавсралт I). Түүнчлэн дэд хорооныхон Монгол улсын Засгийн газрын эрх бүхий байгууллагууд, төрийн албан хаагчид, Монгол Улсад үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Хүний Эрхийн Үндэсний Комисс, иргэний нийгмийн байгууллагын гишүүд болон Монгол дахь НҮБ–аар орж уулзалт хийлээ.

4. Айлчлалын төгсгөлд засгийн газрын эрх бүхий байгууллагууд болон албан хаагчдад төлөөлөгчдийн зүгээс аман хэлбэрээр нууц санал дүгнэлтийг урьдчилсан байдлаар танилцуулсан болно.

5. Тус тайланд ЭШУСДХ–ны олж мэдсэн зүйлс болон Монгол улсад эрүү шүүлт тулгах, зүй бусаар харьцан эрх чөлөөг нь хязгаарлаж байгаа явдлаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

6. Оролцогч улс нь тус тайланг Засгийн газрын холбогдох эрх бүхий байгууллагууд, албан газруудад түгээхийг санал болгож байна.

7. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн Нэмэлт протоколын 16(2)

---

<sup>4</sup> Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн Нэмэлт протоколын 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 2018 оны 03 дугаар сарын 09–ний өдөр Оролцогч Улсад тайлан нууцлан хүргүүлэв. Албан ёсны бөгөөд засваргүй тус баримт бичиг болно.

дугаар зүйлийн дагуу Монгол улс нээлттэйд тооцохоор шийдвэр гаргах хүртэл тус Тайланг нууц хэвээр байлгана.

8. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн Нэмэлт протоколын 16(2)-ын дагуу тус Тайланг хэвлэн нийтлэхийг монголын эрх бүхий байгууллагуудад зөвлөж байна.

9. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн Нэмэлт протоколын 26 дугаар зүйлийн дагуу бий болгосон Тусгай Санд Оролцогч улс анхаарлаа хандуулахыг ЭШУСДХ хүсч байна. ЭШУСДХ-ны айлчлалтай холбоотойгоор хийгдсэн тус тайланд орсон зөвлөмжүүд хэвлэн нийтлэх шалгуурыг хангасан бол тайланг ийнхүү нээлттэй болгосны дүнд тухайн Сангаас тодорхой ашиг тус хүртэх талаар өргөдөл гаргах үндэслэл болох юм.

10. ЭШУСДХ-ноос уулзалтыг төлөвлөх, зохион байгуулахтай холбоотой бүхий л ажилд туслалцаа үзүүлж байсанд эрх бүхий байгууллагуудад талархал илэрхийлж байна.

**II. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн Нэмэлт протоколын хэрэгжилт**

11. Монгол улс 2015 оны 02 сарын 12-ны өдөр Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколыг соёрхон баталснаас хойш нэг жилийн дотор үндэсний урьдчилан сэргийлэх механизм (УСМ)-ыг бий болгох үүрэг хүлээсэн. Соёрхон баталснаас хойш хоёр жилийн хугацаа өнгөрөхөд Оролцогч улс уг ажлыг хийх шатандаа явсаар байна.

12. Урьдчилан сэргийлэх механизмыг ямар бүтэцтэй, ямар загвараар байгуулах талаар Засгийн газар дотоодын зөвлөлгөөн, хяналтуудыг явуулж байгаа гэдгийг ЭШУСДХ-ноос хүлээн зөвшөөрч байна. Өнөөдрийн байдлаар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь урьдчилан сэргийлэх механизм байж болно гэж үзэж байгааг ойлгож байна.

13. Эрх хэмжээ. Монголын Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 3(1) зүйлд заасны дагуу Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхүүлэн дэмжих, тус хуулийн 13 дугаар зүйлийн дагуу Монгол Улс дахь хүний эрхтэй холбоотой аливаа асуудлаар санал гаргах, олон улсын хүний эрхийн гэрээний биелэлт, энэ тухай Засгийн газрын илтгэлийг боловсруулахад санал өгөх үүрэгтэйн зэрэгцээ судалгаа хийх Үндэсний бүс нутгийн олон улсын хүний эрхийн байгууллагуудтай хамтран ажиллах, хүний эрхийн тухай мэдлэгийг дээшлүүлэх, хүний эрхийн боловсролыг дэмжих, олон улсын хүний эрхийн гэрээ хэлэлцээрүүдийг хүлээн зөвшөөрөхийг дэмжих үүрэг хүлээдэг.

14. Газар дээр нь очиж танилцах эрх. 2000 онд анх байгуулагдсанаас хойш Хүний эрхийн Үндэсний Комисс нь цагдан хорих байруудад мэдэгдэх, эсхүл үл мэдэгдэх байдлаар шууд газар дээр нь очиж танилцах, судалгаа хийх, асуулга явуулах зэргээр

хүний эрхэд мониторинг хийсээр ирсэн байна. Хүний эрхийн Үндэсний Комисс нь насанд хүрээгүй хүмүүсийг засан хүмүүжүүлэх төвүүд, нээлттэй болон хаалттай хэлбэрийн хорих ангиуд, цагдан хорих төв, хорих ангийн харьяанд байрлах эрүүл мэндийн төвүүдэд мониторинг хийдэг байна. Бусад эрүүл мэндийн төвүүдэд хяналт шалтгалт хийх эрхийг мөн Хүний эрхийн Үндэсний Комисс эдэлдэг. 2007 оноос хойш Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв дэх сэтгэцийн өвчтэй хүмүүсийн эрхэд мониторинг хийж байгаа болно. Түүнчлэн тайлангуудад дурьдсанаар гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах байр, мансуурах донтой этгээдийг албадан эмчлэх төв, сэтгэцийн клиник төв зэрэг байгууллагуудад газар дээр нь очиж танилцах эрх эдэлдэг. Тусгай асаргаа шаарддаг, хэвийн бус сэтгэцтэй хүмүүс, эрх чөлөөг нь хязгаарлан хүнийг байрлуулж буй байгууллагуудад Хүний эрхийн Үндэсний Комисс байнгын мониторинг хийж, бие даасан байдлаар ажиллах чадвар нь бэхжсэн байгаад НҮБ–н Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос өгсөн зөвлөмжүүд хэрэгжиж байна гэж үзэж байна. ЭШУСДХ–ны айлчлалын үеэр цагдан хорих төвүүдэд Хүний эрхийн Үндэсний Комисс байнга, системтэйгээр газар дээр нь очиж танилцахгүй байгаагаас хоригдлуудтай нэг бүрчлэн ярилцлага хийхгүй байгаа талаар мэдээлэл ирж байсан болно.

15. Комиссын гишүүдийг сонгох. Хүний эрхийн Үндэсний Комисс нь нийт гурван гишүүнтэй. Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1–д “Комиссын гишүүнд нэр дэвшигчийн нэрийг Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Улсын дээд шүүхийн саналыг үндэслэн Улсын Их Хурлын дарга Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ” гэж заасан. Хүний эрхийн Үндэсний Комиссын албан тушаалд сонгох процесс ажиллагааг булхайгүй, ил тод, оролцоог хангасан байдлаар явуулахыг Монгол улсад Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн хорооны зүгээс 2016 онд зөвлөж байсан.

16. Санхүүжилт. Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1–д “Комиссын гишүүний үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана.” гэж заасан. Гэвч Хүний эрхийн Үндэсний Комиссын санхүүжилт болон ажлын албанд ажиллагсдын орон тоо сүүлийн жилүүдэд буурсан байна. Энэ асуудлаар Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос уг асуудлын талаар анхаарал хандуулах ёстойг илэрхийлж байсан.

17. Хууль тогтоомж болон бодлогын асуудлаар санал хэлэх, мэдээлэх. Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1–д “Комисс нь Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар жил бүрийн эхний улиралд багтаан Улсын Их Хуралд илтгэнэ” мөн уг илтгэлийг Төрийн мэдээлэл сэтгүүлд хэвлүүлнэ гэж заасан байдаг. Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулиар хүний эрхийн асуудлаар, түүнчлэн холбогдох олон улсын гэрээний зарчмуудтай захиргааны аливаа шийдвэр нийцэж буй эсэх талаар санал гаргах, зөвлөмж өгөх зэрэг эрхийг Хүний эрхийн Үндэсний Комисст олгосон байна. Эрүү шүүлтээс ангид байх эрхтэй холбоотой зөвлөмжүүдийг жил тутам монголын парламентад зориулж гаргадаг тайланд Хүний эрхийн Үндэсний Комисс дурьдаж байсныг ЭШУСДХ–ноос онцлон тэмдэглэж байна. Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцийн 1 болон 4 дүгээр зүйлд нийцүүлэн дотоодын хууль тогтоомжид өөрчлөлт

оруулж эрүү шүүлт тулгах гэмт хэргийг тодорхойлох нь зүйтэй, мөн эрүү шүүлтийн улмаас хохирсон хүмүүст учирсан материаллаг бус хохирлыг мөнгөн хэлбэрээр үнэлж тооцох, эрүү шүүлтийн улмаас хохирсон хүмүүсийг хамгаалах хуулийн заалтуудыг нэмж оруулах шаардлагатай хэмээн 2014 онд Хүний эрхийн Үндэсний Комисс санал болгож байсан. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах замаар цагдан хорих төвд хоригдож байгаа хүмүүсийг хорих хугацаатай холбоотой зохицуулалт хийхийг хамгийн сүүлийн тайландаа зөвлөсөн байна. Дотоодын хамгаалалтын механизмыг бий болгохтой холбоотой эрх зүйн зохицуулалтын төсөл бэлтгэх ажлын хэсгийг байгуулан ажиллах шаардлагатай талаар мөн Хүний эрхийн Үндэсний Комисс санал болгожээ.

18. Хүний эрхийн Үндэсний Комиссыг үүсгэн байгуулсан хуульд үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг бий болгох зохицуулалт бүхий нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн төсөл боловсруулж, парламентаар ойрын хугацаанд батлуулахыг Оролцогч улсад ЭШУСДХ-ноос анхааруулж байна. Эрх зүйн ямар зохицуулалт хамгийн зохимжтой байхыг Оролцогч улс тодорхойлон шийдвэрлэх бөгөөд үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг үүсгэн байгуулахдаа Нэмэлт протокол, үндэсний урьдчилан сэргийлэх механизмын талаарх Дэд хорооны Удирдамжтай бүрэн нийцсэн байхыг анхаарах нь зүйтэй. Иргэний нийгмийн байгууллага, бусад оролцогчдыг хамруулан ил тод ажиллагааны дүнд олон нийтээр хэлэлцүүлэн үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг байгуулах нь зүйтэй.

19. Үндэсний урьдчилан сэргийлэх механизм байгуулагдсан тохиолдолд бодитоор оршин байгаа эсхүл илэрхий ашиг сонирхолын зөрчлөөс татгалзан чиг үүргээ хэрэгжүүлэх ёстой. Үндэсний урьдчилан сэргийлэх механизмын бүх гишүүд нь ярилцлага хийх, газар дээр нь очиж танилцах процесс, эрүү шүүлт тулгасан, зүй бус харьцсаныг нотлох аливаа шинж тэмдгийг тодорхойлох, эрсдлийг тогтоох ур чадварыг эзэмшүүлэх, ажлын арга зүйг боловсруулах, тухайн институцид тулгарч байгаа бэрхшээл, хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан нь нийгмийн эмзэг хэсэгт хэрхэн нөлөөлж байгаа байдлыг цогцоор тодорхойлох, уулзалт хийхтэй холбоотой арга зүйг эзэмшүүлэх сургалтад хамрагдсан байх шаардлагатай.

20. Үндэсний урьдчилан сэргийлэх механизм байгуулагдсан тохиолдолд төрийн эрх бүхий байгууллагуудтай яриа хэлэлцээ хийх процессыг үргэжлүүлэх, эрх чөлөөг нь хязгаарласан хүний байгаа нөхцөл байдлыг сайжруулах, зүй бус харьцааг өөрчлөх, эрүү шүүлт тулгаж буй байдал, хууль бусаар шийтгэл оногдуулж байгаагаас урьдчилан сэргийлэх зорилгоор уг яриа хэлэлцээрийг үр дүнд хүргэх, тус механизмд хамаарал бүхий зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ёстой. Үндэсний урьдчилан сэргийлэх механизмаас жил тутам Тайлан гаргаж, түүнийг хэвлэн, олон нийтэд түгээх ёстой.

21. Аль болох ойрын хугацаанд үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг бий болгох хууль тогтоомжийг батлах замаар уг тогтолцоог бүрдүүлж Нэмэлт Протоколын дагуу хүлээсэн үүргээ Монгол Улсын Засгийн газар биелүүлэхийг ЭШУСДХ-ноос зөвлөж байна. Уг тогтолцоог бүрдүүлэхдээ Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколын шаардлагууд, ЭШУСДХ-ноос гаргасан урьдчилан сэргийлэх механизмыг бүрдүүлэхэд баримтлах Удирдамжид тусгагдсан шаардлагууд, Парисын Зарчмуудыг

харгалзах, бие даасан үйл ажиллагаа явуулж, чиг үүргээ гүйцэтгэж чадахуйц эрхийг урьдчилан сэргийлэх механизмд олгон, урьдчилан сэргийлэх механизмыг зохицуулсан хуулийг аль болох богино хугацаанд боловсруулж батлах шаардлагатай байна.

22. ЭШУСДХ–ноос бие даасан, үр дүнтэй үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг бий болгохдоо ЭШУСДХ–ноос гаргасан Удирдамжид агуулагдах дараах элементүүдийг эрх бүхий байгууллагууд анхаарахыг зөвлөж байна. Үүнд:

- (a) Нэмэлт Протокол болон Парисын Зарчмуудад тусгагдсан холбогдох зүйл, заалтын дагуу үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг бий болгох;
- (b) Үндэсний урьдчилан сэргийлэх механизмд олгох эрх хэмжээ, бүрэн эрхийг хуульд тусгах, эсхүл үндсэн хуулийн үг хэллэгээр тодорхой илэрхийлэх, үндэсний урьдчилан сэргийлэх механизмын үйл ажиллагаа явуулах бие даасан, хараат бус байдлыг хуулиар баталгаажуулах, практикт бэхжүүлэх;
- (c) Үндэсний урьдчилан сэргийлэх механизмын гишүүд нь бие даасан, хараат бус байхын зэрэгцээ мэргэжлийн мэдлэг тэр дундаа эрүүл мэндийн, сэтгэл зүйн болон өөрийн үүргийг үр дүнтэй гүйцэтгэх шаардлагатай бусад мэргэшсэн мэдлэг, чадварыг эзэмшсэн байх шаардлагатай;
- (d) Үндэсний урьдчилан сэргийлэх механизм нь Нэмэлт Протоколын дагуу гүйцэтгэх өөрийн чиг үүргийг гүйцэтгэж чадна гэдгийг нягтлах хангалттай албан хаагчидтай байх ёстой, мөн өөрийн эрх хэмжээнийг хүрээнд цагдан хорих төвүүдийн тоотой харьцуулж үйл ажиллагаа явуулах чадвартай байх шаардлагатай;
- (e) Үндэсний урьдчилан сэргийлэх механизм үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулахад шаардагдах нөөцөөр хангагдахыг зөвшөөрөх ёстой. Нэмэлт Протоколын дагуу чиг үүргээ хэрэгжүүлэхэд зориулж санхүүгийн болон үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдлаар бүрэн хангагдах шаардлагатай. Үндэсний урьдчилан сэргийлэх механизмын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад, бусад байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөөг гаргахад нөөцийг жилийн төсөвт тусгайлан нэг нэгж болгон оруулж, урьдчилан тооцоолох замаар баталгаажуулна.
- (f) Үндэсний урьдчилан сэргийлэх механизм нь Монгол улсад хангалттай үйл ажиллагаа явуулж чадахгүй байгаа боловч одоогоор оршин байгаа системийг өөрчлөн орлохоос илүүтэй багийн системийг дэмжин, бие биенээ нөхөн хамтран ажиллах, бусад нэмэлт системийг ажиллуулах бололцоог хаахгүй байх;
- (g) Орлоцогч улс үндэсний урьдчилан сэргийлэх механизмаас тодорхойлсон хугацаанд уулзалтуудыг зохион байгуулах боломжоор тус механизмыг хангах шаардлагатай. Үүнд эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүмүүстэй хувийн ярилцлага хийх, мөн Нэмэлт протоколд заасны дагуу эрх чөлөөг хязгаарлаж буй газруудад хэдийд ч урьдчилан мэдэгдэлгүй очих эрх орно.
- (h) Бусад байгууллагууд болон олон нийтийн зүгээс үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг эрүү шүүлтийн эсрэг голлох үүрэг гүйцэтгэдэг байгууллага мөн гэсэн ойлголтой байх ёстой. Эрүүдэн шүүх, зүй бусаар харьцахаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхэд урьдчилан сэргийлэх механизмд олгож байгаа бүрэн эрхийн талаар олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх, энэ талаар

сурталчлах нь ач холбогдолтой гэдгийг ЭШУСДХ–ноос онцлон сануулж байгаа бөгөөд үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг тус улсын системд байгаа эрүү шүүлтээс хамгаалах гол бүрэлдхүүн хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрүүлэх шаардлагатай.

### **III. Ерөнхий асуудлууд**

#### **A. Асуудлын хүрээ**

23. Оролцогч улс нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хуульдаа томоохон өөрчлөлт хийж, өргөн хүрээтэй шинэчлэлт эрүүгийн тогтолцоондоо хийснийг ЭШУСДХ–ноос онцлон тэмдэглэж байна. Мөн цагдан хорих төвүүдийг засварлаж байгааг сүүлийн үед хийгдэж байгаа шинэчлэлийн нэг хэсэг гэж үзэн ЭШУСДХ сайшааж байна. Шинээр хийсэн өөрчлөлтүүд үр дүнд хүрч байгаа хэдий ч тулгамдсан бэрхшээлтэй асуудлууд байсаар байна. Тухайлбал цагдан хорих төвүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн үйлчилгээ, шударга ёсны тогтолцоог бий болгох, цагдаагийн үйл ажиллагааг удирдлагаар хангах бүх үүрэг хариуцлага Хууль зүй, дотоод хэргийн яаманд оногдсон байна гэж ЭШУСДХ үзэж байна. Энэ нь сонирхлын ноцтой зөрчилд хүргэж болох бөгөөд урьдчилан сэргийлэх ойлголтын үүднээс авч үзвэл оновчгүй, эрх мэдлийн хуваарилалтын эсрэг чиглэсэн, цагдан хорих систем болон эрүүгийн шударга ёсны тогтолцоог үр дүнтэй удирдахад хохирол учруулж болзошгүй юм.

24. Цагдаагийн үйл ажиллагааг удирдлагаар хангах болон шударга ёсны тогтолцоог бий болгох үүргийг тусдаа өөр яамдад хариуцуулах ёстой. Түүнчлэн цагдан хорих, саатуулах газарт үзүүлж байгаа эрүүл мэндийг хамгаалах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үүргийг Эрүүл мэндийн яаманд шилжүүлэхийг ЭШУСДХ–ноос зөвлөж байна.

#### **B. Зүй бус харьцах, эрүүдэн шүүх явдал**

25. Төрийн албан хаагчийн эрүү шүүлт тулгасан, зүй бусаар харьцсан үйлдлийн талаарх хэргийг шүүхэд нэн даруй шилжүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнд хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзан шийтгэл оногдуулах, хохирогчдод үр дүнтэй арга хэрэглэх тухайлбал нөхөн сэргээх болон эрүүл мэндийн тусламж үзүүлэх талаар ЭШУСДХ онцолж байна. Түүнчлэн эрүүдэн шүүх, зүй бус харьцах асуудлыг мөрдөн шалгах, баримтжуулан тогтоохтой холбоотой ажил, үүрэг хүлээдэг шүүгч, прокурор, эрүүл мэндийн ажилтнууд болон энэ салбарт хамаарах ажил хийдэг бусад албан хаагчдыг Истанбулын протокол, эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах үйлдлийг зогсоох, тэдгээр үйлдлүүдийг ялгах, ангилах, тусгайлсан эрүүл мэндийн үзлэг хийх зэрэг олон улсын стандартын тухай зохих сургалтад хамруулах боломжоор Оролцогч улс хангах ёстой.

26. 2014 онд Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх тусгай мөрдөн байцаах албыг татан буулгаж, чиг үүргийг Авилгатай тэмцэх газарт шилжүүлсэнд ЭШУСДХ санаа зовниж байна. Тухайн төрийн албан хаагчийн эрүү шүүлт тулгасан, зүй бусаар харьцсан гэх үйлдлийг өөр нэг төрийн албан хаагчаар мөрдүүлж байгаа одоогийн энэ бүтэц нь ижил түвшинд мөрдөн шалгах бие даасан байдал алдагдахад хүргэж, цаашлаад үр дүнтэй хяналтыг бий болохгүй байх хэмээн ЭШУСДХ зовниж байна.

27. Энэ өөрчлөлт нь үр дүнтэй мөрдөн шалгалт явуулах нөхцөл боломжийг бий болгох магадлалыг багасгасан гэж ЭШУСДХ үзэж байгаа учраас эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр гаргах саналын тоог багасгаж, энэ төрлийн хэргийн талаар гомдол мэдүүлэх боломжийг бууруулахад хүргэнэ. Эдгээрийг хамтад нь нэгтгэж авч үзвэл эрүү шүүлт тулгасан этгээд ял завших эрсдлийг нэмэгдүүлнэ.

28. Ийнхүү зовниж буй асуудлыг статистик мэдээнүүд улам баталгаажуулж байна. 2014 оноос хойш хугацаанд мөрдөн шалгалт явуулахаар үүсгэсэн хэргийн тоо улам буурч байгаа бөгөөд хоригдолтой зүй бусаар харьцсан гагцхүү нэг төрийн албан хаагчийг буруутган хорьжээ. Уг асуудлаар Эрүүдэн шүүхийн эсрэг хороог анхаарал хандуулахыг ЭШУСДХ-ноос хүсч, саналаа илэрхийлсэн болно.

29. Төрийн алба хаагчид, түүний дотор цагдаагийн албан хаагчдын үйлдсэн эрүү шүүлт тулгах, зүй бус харьцсан зэрэг үйлдлийг мөрдөн шалгах чиг үүрэгтэй, хараат бус бие даасан нэгжийг Улсын ерөнхий прокурорын газрын дотоод бүтцэд дахин бий болгохыг Орлоцогч улсад ЭШУСДХ-ноос зөвлөж байна. Бүх мөрдөн шалгалтыг хараат бусаар, алагчлалгүй, үр дүнтэй, мөрдөгч болон гэмт хэрэгтнүүдийн хооронд ямар нэг холбоо үүсэхээс сэргийлсэн байдлаар явуулахыг Орлоцогч улс нягтлан шалгах ёстой.

### **С. Гомдол гаргах механизм**

30. Хоригдлууд төдийгүй албан хаагчдын мэдээлснээр хоригдолтой зүй бусаар харьцсан тухай гомдлыг юун түрүүн тухайн хорих байранд ажиллаж буй ажилтанд хаяглан гаргах, шийдвэрлүүлж байгаа нь гомдол шийдвэрлэх бусад боломжит гадны механизмуудад хандахаас өмнө хийгдэж байгаа нь асуудал үүсгэж байна. Бодит байдал дээр ихэнх гомдлыг цензурдэх буюу хянаж байгаа бөгөөд хяналт тавьж гомдол хүлээн авах хөндлөнгийн үр дүнтэй арга хэрэгсэл байхгүй байна гэж ЭШУСДХ үзэж байна. ЭШУСДХ анхаарал хандуулахыг хүсч, саналаа илэрхийлсэн уг асуудлыг Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд гаргасан талаар дээр дурдсан.

31. Зүй бусаар харьцсан талаар гомдол гаргахдаа уг гомдлын агуулгыг нууцлахыг хоригдлуудад зөвшөөрөх үр дүнтэй механизмыг бүрдүүлэхийг Орлоцогч улсад ЭШУСДХ зөвлөж байна. Аливаа хэлбэрийн дотоод (мөн гадаад) хяналтгүйгээр, эсхүл цензургүйгээр, бие даасан, хараат бус, мөрдөн шалгах эрх бүхий байгууллагад гомдлоо шууд гаргах, хамгаалалтын болон эрхийг хамгаалах механизмыг зохих ёсоор бий болгон ажиллуулах хэрэгтэй.

32. Энэ төрлийн гомдол гаргаж байгаа хүмүүст аливаа хэлбэрээр хариуцлага тооцох, тэр дундаа бие махбодийн, сахилгын шийтгэл ногдуулах эсхүл захиргааны арга хэмжээ авахгүй байх ёстой талаар Орлоцогч улс нягтлах ёстой гэж ЭШУСДХ-ноос зөвлөж байна.

## **IV. Эрүүдэн шүүх, зүй бус харьцах байдал**

### **А. Цагдаа**

33. Мөрдөн шалгалт болон баривчлах ажиллагааны эхний үе шатанд тодруулбал алслагдсан цагдаагийн хэлтэс эсхүл жижиг хэмжээтэй хэлтсүүдэд эрүү шүүлт тулгах, зүй бусаар харьцах үйлдлүүд ихээр гардаг талаар олон эх сурвалжаас ЭШУСДХ мэдээлэл

авсан. Тодорхой цагдан хорих, саатуулах төвд газар дээр нь очиж танилцах үед ЭШУСДХ өөрийн хийсэн ажиглалтаар эдгээр мэдээллийн зарим нь батлагдаж, итгэл үнэмшил төрүүлж байсан.

34. Эдгээр зүй бус харьцаа нь гэм бурууг хүлээлгэх, нотолгооны эд зүйлийг эрж олох зэрэгт чиглэгдсэн зорилготой байсан, зодох, зарим цөөн тохиолдолд цахилгаанд цохиулах гэх мэт хэлбэрээр үйлдэгдэж байна. Эрүү шүүлтийн хэлбэрт тооцогдох сэтгэл санааны дарамт зохисгүй байдлаар учруулах, эсхүл зүй бусаар харьцах асуудал байцаалтын эхний үе шатанд мөн ашиглагдаж байна, тухайлбал зүй бусаар харьцах зорилгоор цагдаагийн өөр хэлтэс рүү шилжүүлэхээр заналхийлэх, гэр бүлийн гишүүдийг заналхийлэх, эсхүл гэм бурууг хүлээлгэх эсхүл бусад мэдээлэл өгсөн тохиолдолд гэр бүлийн гишүүдтэй уулзуулах нөхцлийг хоригдолд тавих зэрэг үйлдэл гаргаж байна.

35. Очиж танилцсан ихэнх цагдаагийн хэлтсүүдийн хувьд хяналтын камер болон дуу, дуу-дүрсний бичлэг хийх төхөөрөмжөөр тоноглогдсон байсан ч зүй бус хандлагаар харьцах байдал гарах магадлалтай хамгийн эхний байцаалтыг тухайн хэлтсийн захиргааны өрөөнүүдэд явуулах хандлагатай байгаа байдал илт ажиглагдсан. Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны зөвлөмжүүдийг эргэн сануулахын зэрэгцээ байцаалт авахад зориулан зүй ёсоор тоноглогдсон өрөөнд бүх сэжигтнүүдийг байцаахгүй, уг өрөөг ашиглахгүй байгаа нь зүй бусаар харьцах хандлагыг нэмэгдүүлэх эрсдэлийг бий болгож байна.

### **В. Цагдан хорих байх**

36. Цагдан хорих байранд зүй бусаар харьцаж байгаа талаар зарим мэдээллийг, тухайлбал цагдан хорих байрны тусгаарлагдсан бөглүү хэсгүүдэд бороохойгоор зодох, бүсээр ташуурдах зэргээр хэрцгий байдалтай харьцаж байгаа тухай мэдээллийг (жишээ нь: Цагдан хорих 461 дүгээр анги болон Төв аймгийн цагдан хорих) ЭШУСДХ хүлээж авсан.

### **С. Хорих ангиуд**

37. ЭШУСДХ-ны төлөөлөгчид очиж танилцсан хорих ангиудад сэтгэл санааны хувьд болон бие махбодийн шийтгэл үзүүлж, зүй бусаар харьцсан аливаа үйлдлийн талаар мэдээлэл хүлээн аваагүй.

38. ЭШУСДХ-ноос дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

- a) Цагдаа, мөрдөгчид, шоронгийн ажилтнуудад зориулсан сургалтад зүй бусаар харьцахгүй байх, эрүү шүүлтийг бүрэн хориглох асуудлыг оруулж өгөхийг онцгой анхаарах;
- b) Цагдаа, мөрдөгчид, шоронгийн ажилтнуудад эрүү шүүлт үйлдсэн аливаа үйлдэлд, тэр дундаа заналхийлэх хэлбэрээр бие махбодид эрүү шүүлт тулгах, эрүү шүүлт тулгах аливаа үйлдэлд оролцох, хамтрах зэрэгт хариуцлага тооцдог гэдгийг ойлгуулах, мэдлэгжүүлэх, ноцтой үр дагавар бүхий шинж чанартай тухайн үйлдэл хийсэн цагдаа, мөрдөгч, шоронгийн ажилтнууд ял шийтгэл хүлээлгэх;
- c) Гэм бурууг өөрөөр нь хүлээлгэхэд суурилсан арга барил болон ял шийтгэх ажиллагааг нотлох баримтад суурилсан арга барилаар өөрчлөх;



- d) Байцаалтад зориулан албан ёсоор бэлтгэсэн, зохих ёсоор тоногдсон өрөөнүүдэд бүх байцаалтыг авах.

#### **D. Бусдаас тусгаарлах болон сахилгын өрөөний асуудал**

39. Цагдан хорих төвүүд болон хорих ангиудад сахилга бат сахиулахдаа зөрчил гаргаж байгаа асуудалд анхаарал хандуулж байна. Зарим байруудад тухайлбал цагдан хорих 461 дүгээр ангид сахилгын арга хэмжээ оногдуулах тухай шийдвэрийг гаргах хүртэл гурав хүртэл хоногоор ганцаарчлан хорьж байна. Сахилгын өрөөний нэг адил ганцаарчлан хорих өрөө нь de facto (тухайн үеийн нөхцөл) байдлаар авч үзвэл сахилгын арга хэмжээ оногдуулахаар тогтоосон хамгийн дээд хугацаанаас хэтрүүлсэн хугацаагаар хоригдлуудыг бусдаас тусгаарлан байрлуулахад хүргэж байна. Нэмж хэлэхэд сахилгын өрөөнд байгаа тохиолдолд өдөрт зөвхөн нэг удаа хоол өгч, шөнийн цагаар хөнжил, гудсаар хангаж байгаа нь бүхэл өдрийн туршид хоригдол шалан дээр суух, эсхүл суух суудалгүй байхад хүргэж байна. Сахилгын арга хэмжээ оногдуулсанд гомдол гаргах үр дүнтэй арга хэрэгсэл байхгүй байгаа байдал ажиглагдсан болно.

40. Сахилгын өрөөнүүдийн бүртгэлийг үзэхэд зарим хорих ангид сахилгын өрөөнд ганцаарчлан хорихоор шийтгэх нь одоогийн зохицуулалтын дагуу хамгийн их хугацаа байхаар тогтоосон 15 өдрийн хугацааг оруулан тооцох замаар 45 хүртэл хоног үргэлжилж байна гэж ЭШУСДХ-ноос үзэж байна.

41. Сахилгын арга хэмжээ оногдуулсанд гомдол гаргахыг хоригдлуудад зөвшөөрөх арга хэмжээ авахыг ЭШУСДХ-ноос зөвлөж байна. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд ганцаарчлан хорих арга хэмжээ авагдах ёстой бөгөөд ганцаарчлан хорих, эсхүл сахилгын өрөөнд тусгаарлан байрлуулах хугацааг сахилгын арга хэмжээ оногдуулан байрлуулсан өдрөөс эхлэн тоолох нь зүйтэй. Ганцаарчлан хорих өрөө, сахилгын өрөөг зохих ёсоор тавилгажуулах, тодруулбал өдрийн турш хэвтэх боломжтой байх ортой байх нь зүйтэй. Ганцаарчлан хорих өрөө, сахилгын өрөөнд хоригдож байгаа хоригдлууд бусад хоригдлуудад өгч байгаатай адил хүнсээр хангагдах, зохих агааржуулалт бүхий байгууламжид өдөрт хамгийн багадаа 1 цагийн хугацаатай байрлах боломжийг олгох нь зүйтэй.

42. Ганцаарчлан хорих шийтгэл оногдуулах хамгийн их хугацаа нь үргэлжилсэн 15 хоногоос хэтрэхгүй байгаа гэдгийг Оролцогч улс нягтлах ёстой бөгөөд шийтгэлийн хугацааг үргэлжилсэн байдлаар дараалуулан, эсхүл хойшлуулшгүй гэсэн шалтгаанаар оногдуулахгүй байх ёстойг анхаарах нь зүйтэй.

#### **V. Цагдаагийн үйл ажиллагаа, явц**

##### **A. Цагдан хорих эхний үе шатанд аюулгүй байдлыг хангах**

43. Цагдан хоригдож эхэлсэн өдрөөс хоригдсон хугацааг тооцож байгаа байдал бүх хоригдлуудын хувьд ижил биш байгаа бөгөөд суурь аюулгүй байдлыг хангахгүй байгаа талаар Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос анхааруулж байсныг ЭШУСДХ-ны зүгээс дахин сануулж байна. Цагдаагийн хэлтэст хүргэгдэн ирсэн хүнд, тэр тусмаа алслагдсан нутаг дэвсгэрт буюу сумын хэмжээнд саатуулагдсан хүнд түүний эдлэх эрхийн талаар

сануулдаггүй, ямар учир шалтгааны улмаас тэнд хүргэгдэн ирсэн талаар бараг мэдээлэлгүй байна.

44. Баривчлагдсан этгээд хуульчтай холбогдох эрхтэй талаар онолын хувьд ярьдаг ч бодит байдал дээр энэ асуудал огт хэрэгжихгүй байна. Үүний дүнд хуульчийг байлцуулахыг шаардсан тохиолдолд хүртэл түүнийг байлцуулахгүйгээр байцаалт явуулж байна. Олон тооны этгээд энэ эрхээсээ татгалзаж байгаа нь урьдчилсан сэргийлэх өнцгөөс авч үзвэл анхаарах ёстой асуудалд тооцогдоно. Хоригдлыг хууль ёсоор төлөөлж байгаа тохиолдолд ч гэсэн хуульчтайгаа анх удаа шүүхийн хэлэлцүүлгийн үеэр уулздаг талаар ЭШУСДХ мэдээлэл авсан. Онолын хувьд хууль зүйн туслалцаа авах бололцоотой гэх боловч эрх чөлөөгөө хязгаарлуулсан этгээд үр дүнтэй хууль зүйн зөвлөгөөг даруй авах боломжтой эсэхийг няглахад тогтолцоо үр дүнгүй байна. Зарим сумдад хууль зүйн туслалцаа үзүүлэх хуульч байдаггүйг ЭШУСДХ ойлгож байгаа болно.

45. Олон тохиолдолд гэр бүлийн гишүүд, тэдний садан төрөл, гэр бүлийн гишүүн баривчлагдсан талаар цагдаагаас мэдээлэл авч байгаагүй хэмээн мэдэгдэж байсныг ЭШУСДХ тэмдэглэж байна.

46. ЭШУСДХ–ноос дараах зүйлийг зөвлөж байна. Үүнд:

- a) Баривчлагдсан хүн бүр ямар шалтгааны улмаас баривчлагдсан талаар мэдээлэл авах, өөрийн эрхийн талаар мэдэх боломжтой байх;
- b) Зарим хуульчтай холбоотой байхаас урьдчилан сэргийлэх хууль ёсны үндэслэл байгаагаас бусад нөхцөлд эрх чөлөөгөө хязгаарлуулсан этгээд нь өөрийн сонгосон хуульчтай уулзах эрхтэй байх, түүнтэй холбогдох боломжтой байх ёстой;
- c) Эрх чөлөөгөө хязгаарлуулсан бүх этгээд цаг тухайд, үр дүнтэй туслалцаагаар хангагдаж байгаа эсэхийг нягтлахыг хууль зүйн туслалцааны тогтолцоо шалгаж байх ёстой;
- d) Эрх чөлөөгөө хязгаарлуулсан бүх этгээд өөрийн гэр бүлийн гишүүд, ойрын төрөл садандаа хоригдож байгаа талаар даруй мэдээлэх боломжтой байх ёстой. Уг эрхийг хэрэгжүүлэхдээ цагдан хорих төвийн захиргаа, мөрдөгч, прокурор, цагдан хорих шийдвэр гаргасан эрх бүхий байгууллага эсхүл тодорхой хүчин чармайлт гаргах шаардлага зэргээс үл хамааралтайгаар эрхээ эдэлнэ.

## **В. Цагдан хорих хууль зүйн дэглэмтэй холбоотой асуудлууд**

### **Цагдан хорих**

47. Мэдүүлэг авах зорилгоор хүнийг цагдаагийн хяналтад 6 цагаас хэтрэхгүй хугацаанд саатуулахаар хуулиар зохицуулсан ч бодит байдал дээр прокурор эсхүл шүүхийн хяналтгүйгээр уг тогтоосон хугацаанаас илүү хугацаагаар саатуулж байгаад ЭШУСДХ анхаарлаа хандуулж байна. Зарим онцгой тохиолдолд уг хугацааг 48 цаг хүртэл хугацаагаар цагдаа сунгах боломжтой талаар, мөн хойлшлуулшгүй гэсэн тохиолдолд бус ихэнх тохиолдолд мөрдөгчийн ажлын бус цаг болох долоо хоногийн сүүлийн хоногуудыг тооцон цагдаа мэдүүлэг авах хугацааг 48 цаг хүртэл сунгаж байгаа талаар ЭШУСДХ мэдээлэл авсан.

48. Цагдаа анх удаа мэдүүлэг авах зорилгоор хүнийг саатуулахдаа тухайн саатуулсан хүмүүсийн талаар бүртгэл хөтлөхгүй байгаа байдал зарим цагдаагийн хэлтэс, тэр дундаа хөдөө орон нутгийн хэлтсүүдэд гарч байгаад ЭШУСДХ анхаарал хандуулж байна. Саатуулсан хүнийг түр хугацаагаар саатуулах, цагдан хорихоор байрлуулах, эсхүл аймгийн цагдаагийн газарт шилжүүлэх тохиолдолд мэдүүлэг авсан хэмээн бүртгэж байгаа байдал нь цагдаагийн мөрдөгч мэдүүлэг авсан хүмүүсийнхээ талаар системтэй бүртгэл хөтөлдөггүй байгаа бодит байдлыг харуулж байгаа юм.

49. Цагдаагийн байранд мэдүүлэг авахаар 48 цаг хүртэл хугацаанд байлгахдаа цагдаагийн албан ажлын байрны коридор зэрэг зохисгүй газарт байлгаж байгаа талаар ЭШУСДХ мэдээлэл авч, анхаарал хандуулж байна. Түүнчлэн ихэнх тохиолдолд саатуулагдсан хүнд хоол, унд өгөхгүй, ариун цэврийн өрөөнд ороход хатуу хязгаарлалт тогтоож байгаа байдал байсаар байна. Анх удаа мэдүүлэг өгөх хугацааны туршид зарим саатуулагдсан этгээдэд гав зүүлгэдэг гэв.

50. Цагдаа болон прокурорын ойр харилцаа нь цагдаагаас прокурорт танилцуулж буй хэргийг үнэлж, дүгнэн шалгахгаас илүүтэйгээр байгаа баримт материалд гарын үсэг зураад явуулчих байх гэсэн сэтгэгдлийг төрүүлж байгаа талаар ЭШУСДХ ойлгож байна.

51. ЭШУСДХ–ноос дараах зүйлийг зөвлөж байна. Үүнд:

- a) Хуульд заасан хугацаанаас анхны мэдүүлэг авах хугацааг хэтрүүлэхгүй байх, эрх чөлөөг нь хязгаарласан тэр цаг мөчөөс уг хугацааг тоолж эхлэх шаардлагатай. Уг хугацааг сунгах тохиолдолд бие даасан эрх бүхий байгууллагаас хуульд заасны дагуу зөвшөөрөл өгсөн байхыг шаардах;
- b) Анх саатуулсан хугацааг бүртгэлд тодорхой тусгах хэрэгтэй. Цагдаагийн ахлах ажилтнууд уг бүртгэлд хяналт тавих үүрэг хүлээж, цагдаагийн бусад албан хаагчид бүртгэл хөтлөхтэй холбоотой зохих сургалтад хамрагдан, бүртгэлийг цааш хөтлөдөг байх;
- c) Саатуулсан этгээдийг хорьж байх хугацаанд хоол, хүнсээр ядаж ундны усаар хангахын зэрэгцээ ариун цэврийн өрөө ашиглахыг зөвшөөрөх;
- d) Саатуулсан этгээдийг хорьж байх хугацаанд зохих байранд байлгах;
- e) Прокурор, шүүхийн хяналт зөвшөөрөлгүй түр хугацаагаар хорих, цагдан хорьж саатуулж буй байдлыг даруй зогсоох;
- f) Мэдүүлэг авахаар саатуулах, түр хугацаагаар саатуулах, цагдан хорих хугацааг сунгах хүсэлтийг прокурор хянахдаа цагдаагаас хараат бусаар хянах.

Захиргааны журмаар албадан саатуулах болон эрүүлжүүлэх төвүүд

52. Оролцогч улсад гарч буй гэр бүлийн хүчирхийлэл, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэх талаар авч буй алхамуудыг ЭШУСДХ сайшаан тэмдэглэж байна. Захиргааны журмаар албадан саатуулж байгаа процесс ажиллагаа нь шүүхийн зохих хяналт, эрх зүйн хамгаалалт эдлэхгүйгээр дур зоргоор албадан байршуулах хэлбэрээс үүсэх эрсдэлийг дагуулах боломж бүрдүүлж байна. Захиргааны зөрчил гаргасны дүнд эрүүлжүүлэгдсэн, эсхүл зөрчил гаргасан боловч эрүүлжүүлэгдээгүй этгээдийн хооронд бодит ялгаа байхгүй байгаад анхаарал хандуулж байна. Гэр бүлийн хүчирхийллийг эрүүгийн хэрэг гэж үзэхээс илүүтэй захиргааны зөрчил гэж үзэж байгаад ЭШУСДХ анхаарал хандуулж байна.

53. Эрүүлжүүлэх төвүүдэд, мөн захиргааны журмаар албадан саатуулагдаж байгаа этгээдүүдэд тэдний эдлэх эрхийн талаар, мөн ямар хугацаагаар саатуулагдсан талаар, эрүүлжүүлэх төвд ирсэн даруй эрүүл мэндийн үзлэгт хамруулах эсэх талаар мэдээлэл өгдөггүй талаар ЭШУСДХ авч үзэж байна.

54. ЭШУСДХ–ноос дараах зүйлийг зөвлөж байна. Үүнд:

- a) Согтууруулах ундааны нөлөөнд байхдаа захиргааны зөрчил гаргасан хэмээн сэжиглэгдэж буй этгээдийг согтууруулах ундаа хэрэглэсэн байдалтай байгаа сэжигтнээс тусад нь байрлуулах, мөн саатуулагдах үед ямар нөхцөл байдалд байсныг нь харгалзан тохирсон байдлаар хандах;
- b) Согтууруулах ундааны нөлөөнд байхдаа саатуулагдан этгээдийг саатуулах байранд ирсэн даруй цусан дахь согтууруулах ундааны концентрацийг (BAC) хэмжих ёстой бөгөөд ийнхүү хэмжилт хийснээр цусан дахь концентраци нь зохих ёсны, тогтсон заагийг давсан эсэх талаар мэдээлэлтэй болно;<sup>5</sup>
- c) Эрүүлжүүлэх төвд саатуулагдсан этгээд өөрийн эрхийн талаар, ямар шалтгааны улмаас саатуулагдаж байгаа, ямар хугацаанд саатуулагдах, хуульд заасан (24 цаг хүртэл) дээд хугацаанаас хэтрэхгүй хугацаанд албадлага хэрэглэх талаар мэдээлэл авах ёстой. Ийм төвүүдэд саатуулагдсан этгээдийг гэр бүлийн гишүүд, садан төрлийн хүмүүстээ мэдэгдэхийг зөвшөөрөх ёстой бөгөөд хүргэгдэн ирэх үед эрүүл мэндийн үзлэгт хамрагдах, шаардлагатай тохиолдолд хуульч болон эмчтэй уулзах боломжтой байх ёстой.

55. Хуульд заасан дээд хугацаанаас илүү хугацаагаар захиргааны зөрчил гарган сэжиглэгдэж буй хүмүүсийг албадан саатуулж байгаа талаар ЭШУСДХ онцолж байна. Захиргааны журмаар албадлага хэрэглэн хүмүүсийг саатуулахад эрх бүхий шүүх оролцдог хэдий ч ийнхүү оролцож байгаа нь хэлбэр төдий байна. Түүнчлэн захиргааны журмаар саатуулагдсан этгээдүүдийн хэлснээр саатуулах шийдвэрт гомдол гаргах боломж бодит байдалд байдаггүй, гомдол гаргах хугацаа хэт тулсан байдаг бөгөөд гомдол гаргасан тохиолдолд уг гомдлыг авч үзэх үед саатуулсан албадлагын хугацаа дууссан байдаг байна.

56. Хуульд заасан хугацаанаас хэтрүүлэн захиргааны журмаар албадлага хэрэглэн түр хугацаагаар саатуулж байгааг оролцогч Улс нягтлахыг ЭШУСДХ–ны зүгээс зөвлөж байна. Захиргааны зөрчил гаргасны төлөө албадан саатуулах тогтоолыг бүрэн хэмжээгээр зохих ёсоор шүүхийн хяналт дор гаргах ёстой бөгөөд саатуулагдсан этгээдүүд эрх зүйн бүхий л хамгаалалт эдлэх боломжоор хангагдах шаардлагатай. Захиргааны журмаар албадан саатуулах тогтоолд гомдол гаргах үр дүнтэй арга хэрэслэлийг бодит байдалд бий болгох нь зүйтэй.

### **С. Цагдаагийн хэлтсүүдэд саатуулан хорих материаллаг нөхцөл байдал**

57. Газар дээр нь очиж танилцсан эрүүлжүүлэх төвүүд болон түр хугацаагаар саатуулах байрнуудын нөхцөл байдлын талаар ЭШУСДХ–ноос онцгой анхаарал хандуулж байна.

<sup>5</sup> Уг хэмжээг 0,02% байх ёстой гэж зарим цагдаагийн хэлтэсүүдээс SPT мэдээлэл авсан.

Эдгээр байрнуудын ихэнх нь байгалийн гэрэл сайн тусдаггүй, агааржуулалт муутай, хэт чийглэг орчинтой, газар дор байрласан байсан. Хэт олон хүн бөөгнүүлсэн байдалтай биш боловч өрөөнүүдэд шаардлага хангахааргүй ор, дэрний хэрэглэлтэй байсан. Эрүүл ахуйн болон ариун цэврийн нөхцөл байдал нийтлэг байдлаараа шаардлага хангахааргүй муу нөхцөлтэй. Хоол хүнс, ундны зүйлээр огт хангадаггүй болох нь илт байсан.

58. Эрүүлжүүлэх төвүүд болон цагдаагийн түр хугацаагаар саатуулах байрнуудын нөхцөл байдлыг сайжруулах, байгалийн гэрэлтэй, агаажуулалттай, ариун цэврийн асуудлыг анхаарсан олон улсын стандартад нийцсэн хэмжээнд хүргэх арга хэмжээ нэн даруй авахыг Оролцогч улсад ЭШУСДХ-ноос зөвлөж байна. Хоол хүнс, ундны зүйлээр саатуулагдсан хүмүүсийг зохих үндэслэлээр хангах шаардлагатай.

#### **D. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний систем**

59. Цагдаагийн хэлтэсүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ одоогоор байхгүй байгаад ЭШУСДХ-ноос анхаарал хандуулж байна.

60. Албадан саатуулах эхний шатанд бие даасан байдлаар үйл ажиллагаа явуулдаг эмч эрүүл мэндийн үзлэг хийх, саатуулагдсан этгээдийг үзлэгт хамруулж, энэ талаар зохих ёсоор бүртгэл хөтлөх шаардлагатай гэж ЭШУСДХ-ноос зөвлөж байна. Хэрэв саатуулагдсан этгээд шаардсан тохиолдолд түүнд эсхүл түүний хууль ёсны төлөөлөгчид эрүүл мэндийн үзлэгийн талаарх бүртгэлийг үзүүлдэг байх шаардлагатай. Шүүх эмнэлгийн бүх ажилтнууд Истанбулын Протоколын талаар мэдлэг олгох сургалтад сууж, эрүү шүүлт, зүй бус харьцсан үйлдлийг зогсоох, тогтоох, баримтжуулахад шаардлагатай зайлшгүй арга хэрэслийн талаар мэдлэг олж эзэмших нь зүйтэй.

### **VI. Хорих анги (цагдан хорих болон ял эдлүүлэх)**

#### **A. Цагдан хорих төв**

61. 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа шинэ хуулийн зохицуулалтын хүрээнд цагдан хорих хамгийн дээд хугацааг 24 сар байсныг 18 сар болгон бууруулсан нь цагдан хорих төвд хоригдож байгаа хүмүүсийн тоо буурахад хүргэснийг ЭШУСДХ-ноос сайшааж байна.

#### **Эрх зүйн дэглэм**

62. Цагдан хорих хугацааг сунгах асуудал ихэнх тохиолдолд прокурор хоригдож буй хүнтэй холбогдох замаар явагдаж, шүүхийн хэлэлцүүлгийг хоригдогч этгээд болон түүний хуульчийг байлцуулан хийлгүй шийдвэр гаргадаг байна. Тухайлбал, цагдан хорих шийдвэр гаргаж буй шүүгчтэй огт уулзуулалгүйгээр 15 сарын хугацаанд цагдан хорих байранд байлгасан нэг хэргийн талаар ЭШУСДХ мэдээлэл авсан байна. Шүүх хурлын үед цагдан хоригдож буй этгээд болон түүний хуульчийн зүгээс эрүү шүүлт болон зүй бус харьцсан асуудлыг хөндөж тавих нь эрүү шүүлтийн эсрэг чухал хамгаалалт болдог бөгөөд хэрэв зүй бус харьцсан талаар бодит байж болохуйц de facto факт тогтоогдсон бол шүүгчийн зүгээс бусдаас хараат бус, үр дүнтэй мөрдөн шалгалт хийх шийдвэрийг даруй гаргах ёстой байдаг.

63. Тухайн этгээдийг цагдан хорих, цагдан хорих хугацааг сунгах шийдвэр гаргахдаа шүүгч нь тухайн цагдан хоригдож буй хүнийг сонсож байж шийдвэрээ гаргаж буй эсэхийг Оролцогч улс нягтлахыг ЭШУСДХ-ноос зөвлөж байна.

**Гадаа гаргах болон гадаад ертөнцтэй холбоо тогтоох**

64. Цагдан хоригдож байгаа хоригдлуудад зориулсан өрөөнөөс гадуур ямар нэг үйл ажиллагаа гэж байдаггүй талаар ЭШУСДХ-ноос онцгойлон анхаарч байна. Долоо хоногт нэг удаа 15–30 минутын хугацаатай өрөөнөөс гарахыг цагдан хоригдож буй хүмүүст зөвшөөрдөг байна. Энэ хугацааг өрөөнөөс гарахад өдөр тутам хамгийн багадаа 1 цаг байх ёстой олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартаас хэт бага хугацаа байна гэж үзэж байна. Ийм богино хугацаанд хоригдлуудын хувьд хамгийн тохиромжтой байх ёстой зүйлээр тухайлбал агаарт гаргах, биеийн тамирын дасгал хийх гэх мэт үйлдлүүд хийх боломж хязгаарлагдмал байгаа бөгөөд дасгал хийх зай хүртэл хангалтгүй байсан. Жишээлбэл Төв аймаг дахь цагдан хорих байранд хорих өрөөнөөс гадагш гаргахдаа хоригдлуудыг хоёр хоёроор нь холбон гавласан байв.

65. Иймэрхүү хязгаарлагдамал боломж нөхцлийг улам дордуулсан нэг зүйл бол цагдан хоригдож буй хүмүүс уулзалт хүлээж авах явдал байв. (Ойролцоогоор нэг долоо хоногт хоёр удаа тус бүр 20 минут хугацаатай) 461 дүгээр цагдан хорих төвд байгаа хүмүүсийн хувьд гэр бүлийнхэнтэйгээ уулзах асуудлыг прокурорын зөвшөөрөлтэй хийж байсан бөгөөд ямар нэг байдлаар утсаар ярих, захидал илгээхийг зөвшөөрдөггүй байна.

66. Цагдан хорих төвд хоригдож байгаа бүх хүмүүсийг өрөөнөөс гадуур байлгахад алхах, дасгал хийх зэргийг зөвшөөрөхийн зэрэгцээ өдөрт хамгийн багадаа нэг цаг зарцуулах боломжтой байлгахыг ЭШУСДХ-ноос зөвлөж байна.

67. Цагдан хоригдож байгаа хүмүүс уулзалт хийх нь прокурорын эрх хэмжээний асуудал биш байх, уулзалтын өрөөний хэмжээ болон хувийн байдлыг хангасан зохих нөхцлийг бүрдүүлсэн байр байгууламжид хангалттай тооны давтамжтайгаар уулзалт хийгдэж буй эсэхийг нягтлахын тулд уулзалтын нөхцөл байдлыг эргэн хянахыг ЭШУСДХ-ноос мөн зөвлөж байна.

**Материаллаг нөхцөл байдал**

68. 461 дүгээр цагдан хорих төвд байгаа зарим өрөөг үл тооцвол хэт олон хүн нэг өрөөнд байрлуулсан байдал ЭШУСДХ-д ажиглагдаагүй. Гэвч цагдан хорих төвийн албан ёсны хүчин чадал нь нийт хоригдлуудын эзлэх хувьтай тохирохгүй бол зарим цагдан хорих төв тухайлбал Төв аймгийн цагдан хорих байр олон хүнийг нэг дор олноор байрлуулахад хүрч болохоор байна. Газар дээр нь очиж танилцсан барилга байгууламжууд газар дор байрлалтай эсхүл засвар хийсэн байдалтай байв. Засвар хийгдсэн барилга байгууламжийн хувьд материаллаг нөхцөл байдал ерөнхийдөө зөвшөөрөгдөх хэмжээнд байсан боловч зарим нэг дутагдал ажиглагдсан. Жишээ нь зарим өрөөнд ил бие засах хэсгийг CCTV камераар хянаж байсан. Эрэгтэй, эмэгтэй хоригдлуудын аль алины хувьд наад захын ариун цэврийн эд зүйлсийг гэр бүлийхэндээ захиж авчруулах, эсхүл өөрсдөө худалдан авах нөхцөлд байсан.

69. Цагдан хорих байруудад ор дэрний нөхцөл шаардлага хангахгүй тодруулбал орны

даавууг хангалттай сольж өгдөггүйг ЭШУСДХ–ноос тэмдэглэж байна. Тодруулбал 461 дүгээр цагдан хорих төвд өөр хорих анги руу шилжүүлж буй хоригдлууд, түр хугацаагаар буюу 48 цаг хүртэл хугацаагаар саатуулагдаж буй этгээдүүдэд ор дэрээр огт хангадаггүй байна.

70. ЭШУСДХ–ноос дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

- a) Цагдан хорих төвүүдэд засвар хийх төлөвлөгөө нь олон улсын стандартын дагуу бүрэн хийгдэж буй эсэхийг Орлоцогч улс нягтална. Тодруулбал хорих өрөөнүүд боломжит хэмжээтэй, зохих ариун цэврийг хангасан, хангалттай гэрэлтэй, агааржуулалт хэвийн, ортой байх ёстой;
- b) 461 дүгээр цагдан хорих төвийн шилжүүлэг хийх хэсэгт хэт олон хүн бөөгнөрсөн байдалтай байгааг юун түрүүнд шийдвэрлэх;
- c) Бүх хоригдлуудыг ороор хангах, ор дэрний даавууг аль болох ойр хугацаатай тогтмол сольж байх.

### **В. Хорих анги**

71. Хорих ангийн байрыг засварлах тал дээр гол дэвшил гаргаж байгаад Орлоцогч улсыг ЭШУСДХ–ноос сайшааж байна. Түүнчлэн цаазаар авах ялыг халсан, цаазаар авах ялтай байсныг 20 жил бүх насаар нь хорих ялаар сольсон зэрэг шинэ Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд оруулсан бусад өөрчлөлтүүд нь хорих ангид ял эдэлж буй хоригдлын тоог бууруулаад зогсохгүй хэт олноор нь нэг дор хорьж байсан асуудлыг хөнгөвчилсөн.

### **Ерөнхий асуудал**

#### **Ажиллах боломж**

72. Хоригдлууд ажил хийх өргөн боломж байгааг ЭШУСДХ онцлон тэмдэглэж байна. Гэсэн хэдий ч нээлттэй, хаалттай дэглэмтэй хорих ангиудын аль алинд энэ боломжийг ашигласны төлөө тэр бүр хөлс тооцохгүй байгаад ЭШУСДХ анхаарал хандуулж байна.

73. Хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу зохистойгоор зохицуулагдсан ажлын нөхцлийн хүрээнд шударгаар хөлс олгон ажиллуулах боломж бүх хоригдлуудын хувьд адил боломжтой байх ёстойг ЭШУСДХ–ны зүгээс зөвлөж байна.

#### **Хорих ангийн дэглэм**

74. Хорих ангийн дэглэмд хамаарах зарим асуудал нь хэт хязгаарлагдсан байгаад ЭШУСДХ анхаарал хандуулж байна. Тухайлбал газар дээр нь очиж танилцсан хорих ангиудын хувьд шинээр ирсэн хоригдлуудад эхний 14 хоногийн хугацаанд өрөөнөөсөө гарахыг зөвшөөрдөггүй байна. Ажилд гараагүй хоригдлуудын хувьд нэг долоо хоногт хоёроос гурван удаа маш богино хугацаагаар өрөөнөөс гарахыг зөвшөөрдөг, харин хамгаалалт өндөртэй хорих ангиудын хувьд өрөөнөөс гадна байх хугацаанд задгай дээвэртэй өрөөнд байлгадаг байна.

75. 2017 онд шинээр батлагдсан хуулиудад хоригдож байгаа хүмүүсийг гадна ертөнцтэй холбогдох боломжийг олгосныг ЭШУСДХ сайшааж байна. Өндөр

хамгаалалттай хорих ангиудад жилд ердөө дөрвөн удаа уулзалт хүлээн авахдаа нэг удаад гурваас дөрвөн цагийн хугацаатай уулзахыг зөвшөөрч байгаа бөгөөд хоног өнгөрүүлж уулзахыг огт зөвшөөрдөггүй. Хаалттай хорих дэглэмтэй ангид ял эдэлж буй хоригдлуудын хувьд уулзалт хийх давтамжийг бууруулсан. Захидал, шуудан илгээх, хүлээн авахыг, утсаар холбогдон харилцах боломжит тоог нэмэгдүүлжээ. Түүнчлэн уулзахаар зорин ирж буй гэр бүлийн гишүүд хорих анги хүртэл ирэх, буцахад зарцуулсан хугацаа, ийнхүү уулзалт хийх болгонд зарцуулж буй зардал зэрэгтэй харьцуулахад уулзалтын хугацаа хэт богино хязгаарлагдсан байгаа талаар хоригдлууд гомдолложээ.

76. ЭШУСДХ дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

- a) Хорих ял эдэлж буй бүх хоригдлууд ял эдэлж эхлэх үеэс өрөөнөөс гадна гарч зорилтот болон бусад олон нийтийн арга хэмжээнд оролцох боломжоор хангагдах ёстой;
- b) Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хамгийн бага хугацаа буюу өдөрт хамгийн багадаа нэг цагийн хугацаанд агаарт гарч хөдөлгөөн хийх, биеийн тамирын үйл ажиллагаанд оролцохыг бүх хоригдлуудад зөвшөөрөх;
- c) 2017 оны 07 дугаар сард батлагдсан хуулиар зохицуулахдаа гэр бүлийн гишүүдийн хийх уулзалт болон гадаад харилцаа холбоо тогтооход тавьж буй хэт хязгаарлагдмал хатуу журмыг хүчингүй болгох, илүү ойр хугацаанд олон давтамжтайгаар холбогдох, хорих анги хүртэл ирэх, буцахад зарцуулж буй хугацаа, зардал зэрэгтэй холбогдон үүсдэг хүндрэлүүдийг харгалзан үзэж уулзалтын хугацааг илүү урт хугацаатай болгох.

### **Бий болгох шаардлагатай байгууламж**

77. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан байгууламж тэр дундаа хорих газрын тодорхой хэсгүүд болох усанд орох газар, бие засах газарт мөн хоригдлыг хорих өрөөнд байлгахаас бусад зорилгоор үйл ажиллагаа явуулах хэсэгт нэвтрэх боломжтой байгууламж огт байхгүй байгааг ЭШУСДХ-ны зүгээс ажиглав.

78. Хорих системд бүхэлд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй, байх ёстой байгууламжуудыг барьж, бий болгохыг ЭШУСДХ-ноос зөвлөж байна.

79. ЭШУСДХ-ны газар дээр нь очиж танилцсан зарим хорих ангиудад барилга байгууламжийн гадна хэсэгт шоронгийн нэг хэсэг болох жорлон, усанд орох газар байрлаж байгаад, мөн зарим тохиолдолд зөвхөн бие засах хэсэг нь байгаль дээр ил задгай нүхэн хэлбэртэй байгаад анхаарлаа хандуулж байна.

80. Хорих ангиудын барилга байгууламжийн дотор хэсэгт шоронгийн барилгын нэг хэсэг байхаар, эсхүл тодорхой байдлаар холбогдсон байхаар ариун цэврийн хэсэг болох байгууламжийг бүх хорих ангиудад хийхийг ЭШУСДХ-ны зүгээс зөвлөж байна.



## Онцгойлон анхаарах зүйл

### 405 дугаар хорих анги

81. Гэр бүлийн гишүүд нь хоригдлуудтай уулзахаар ирэх үед камераар тоногдлогдсон өрөөнд хөлийг нь шалтай төмрөөр тушсан байдалтай байлган, шоронгийн хуяг байлцан уулзалт хийлгэж байна.

82. Ийм төрлийн байдалтай уулзалт хийлгэхийг даруй зогсоох, гэр бүлийн уур амьсгалыг бүрдүүлсэн, тэдэнд ээлтэй уур амьсгал дор буюу аюулгүй байдлыг арай бууруулсан байдалтайгаар уулзалт хийхийг зөвшөөрөхийг ЭШУСДХ-ны зүгээс зөвлөж байна.

83. Хоёр долоо хоног тутамд нэг удаа усанд орохыг хоригдлуудад зөвшөөрч байна. Энэ байдлыг илүү ойрхон давтамжтай байхаар буюу нэг долоо хоногт нэг удаа байхаар өөрчлөхийг ЭШУСДХ-ноос зөвлөж байна.

### 407 дугаар хорих анги

84. Гэр бүлийн гишүүд урт хугацаагаар эргэлт хийхээр ирсэн тохиолдолд байрлаж барилга байгууламжийн стандарт нөхцлийг тэр дундаа усанд орох газар байхгүй байгаа байдал, ариутгал хийгддэггүй, ариун цэврийн нөхцөл хангаагүй гадна жорлон зэрэгт анхаарал хандуулж байна.

85. Уулзалтын хэсгийн нөхцлийг сайжруулах, тэр дундаа барилга дотор жорлонтой, угаалтууртай болохыг ЭШУСДХ-ноос зөвлөж байна.

### 415 дугаар хорих анги

86. Нийтийн жорлон болон бие угаах хэсгийн ихэнх нь хүний хувийн байдлыг хамгаалах нөхцөл бүрдээгүй байна, тухайлбал тусгаарлагч нь хэтэрхий намхан, жорлон нь шилэн хаалгатай, камераар хянадаг зэрэг байдалтай байна.

87. Хүний хувийн байдлыг зохих түвшинд хянаж буй эдгээр нөхцөл байдлыг эргэж харахыг ЭШУСДХ-ны зүгээс зөвлөж байна.

### 421 дүгээр хорих анги

88. Газар дээр нь очиж танилцсан бусад хорих ангиудтай харьцуулахад тус хорих ангийн барилгын гадна байрлах салангид хэсэгт жорлон байрлаж байсан. 421 дүгээр хорих ангийн хувьд тодорхой тооны хөгжлийн бэрхшээлтэй хоригдлууд тэр дундаа ахимаг настай эсхүл өвчтэй хоригдлуудын хувьд бие засах газар хүрэхэд амаргүй байгаа нь харагдаж байсан. Тус хорих ангийн зүгээс тусгай хэрэгцээ эсхүл бусад байдлаар эмзэг хүмүүст таарсан хөдөлгөөн, хоол хүнсний хэрэгцээг хангаж чадахгүй байв.

89. Хорих ангийн бүхий л хэсэгт бүрэн хэмжээгээр, тодруулбал зохих барилга байгууламж шаардлагатай байгаа хүмүүс байгаа эсэхийг тодруулж нягтлахыг ЭШУСДХ-ны зүгээс зөвлөж байна. Хоол хүнс, ус болон ариун цэврийн байгууламжид хүрэх боломж, амралтын үйл ажиллагаа болон бусад үндсэн эрхийг олон улсын стандартын дагуу хангаж байгаа эсэхийг нягтлах ёстой. Хоол хүнс зэрэг тусгай хэрэгцээтэй, онцгой халамж шаардлагатай байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахимаг настан болон хоригдлуудад уг хэрэгцээг хангахад анхаарах ёстой.

## С. Эрүүл мэндийн тогтолцоо

### Ерөнхий асуудлууд

#### Эмнэлгийн ажилтнуудын бие даасан байдал

90. 401 дүгээр хорих ангийн дэргэдэх нэгдсэн эмнэлэг, 461 дүгээр хорих ангийн дэргэдэх эмнэлэг, ХДХВ болон сүрьеэ өвчтөнг хорих 429 дүгээр хорих анги, Баян сум дахь согтуурах, мансуурах донтой этгээдийг албадан байршуулах төв зэрэг хоригдлуудыг байрлуулдаг эрүүл мэндийн хэд хэдэн газраар Хорооноос газар дээр нь очиж танилцсан байна. Хэдийгээр эдгээр байгууламжууд цэвэр цэмцгэр, нарны гэрлийн тусгал сайтай байсан ч байшингууд хэт хуучирсан байв. Албан хаагч, ажилтнуудын тоо хангалттай хэмжээнд, хүн бөөгнөрсөн, хэт олон тоогоор байрлуулсан байдал огт ажиглагдаагүй болно. Бие махбодид зүй бусаар халдсан талаар ямар нэг гомдол ЭШУСДХ хүлээж аваагүй. Засан хүмүүжүүлэх үйлчилгээнээс бие даасан, хараат бус байдлаар эмнэлгийн ажилтнууд ажиллахгүй байгаад ЭШУСДХ анхаарал хандуулсан хэвээр байгаа.

91. Эрүүгийн хэргийн шударга ёсны тогтолцоог бүрдүүлэгч байгууллагуудаас үзүүлж буй эрүүл мэндийн үйлчилгээг хариуцан үзүүлэх нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн яамны чиг үүрэгт хамаарах ёстой. Энэ нь тэгш байдлаар хандах, нэгдмэл байдлыг хангах олон улсын зарчмуудад нийцэх бөгөөд уг асуудалд Оролцогч улс анхаарал хандуулахыг ЭШУСДХ-ны зүгээс санал болгож байна. Эрүүл мэндийн яам нь хорих, цагдан хорих төвүүдэд хоригдож байгаа хүмүүс бусад хоригдоогүй хүмүүстэй адил хэмжээнд эмнэлгийн тусламж авч байгаа эсэхийг нягтлан шалгах үүрэгтэй.

#### Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ

92. Эмнэлгийн анхны үзлэгийг хорих төвд ирсэн даруй хийж байгаа боловч цагдаагийн албан хаагчийг байлцуулан үзлэгийг явуулж байгаа нь тодорхой байна. 461 дүгээр цагдан хорих төвд энэ төрлийн эмнэлгийн үзлэгийг зарим үед коридорт буюу нийтийн эзэмшлийн хэсэгт хийдэг тухай мэдээллийг ЭШУСДХ хүлээн авсан. Эмнэлгийн анхны үзлэгийн талаарх баримт ерөнхий буюу өнгөц байдлаар, тодруулбал тухайн үед ил байгаа гэмтлийг тодорхойлоогүй, ямар нөхцөлд уг гэмтэл үүссэн зэрэг шаардлагатай нарийвчилсан мэдээлэл тэмдэглэгдээгүй байсныг ЭШУСДХ ажигласан. Түүнчлэн хоригдлын эрүүл мэндийн түүх бүхий хавтаст эмнэлгийн анхны үзлэгийн үр дүнгийн талаар тэмдэглэл хийгддэггүй байна.

93. Эмнэлгийн ажилтнууд Истанбулын протокол, холбогдох олон улсын стандартын талаар ерөнхий мэдлэггүй байсан. Иймд эмч нар эрүү шүүлт тулгасан, эсхүл зүй бусаар харьцсан гэдгийг илэрхийлэх хүчин зүйлсд анхаарал хандуулж чаддаггүй байх магадлалтай байдлыг ЭШУСДХ авч үзэж байна.

94. Хорих төвд ирж байгаа этгээдэд эмнэлгийн үзлэг хийх, уг үзлэгийн үеэр илрүүлсэн гэмтлийн талаар зүй ёсоор тэмдэглэн үлдээх нь эрүү шүүлт тулгах, зүй бусаар харьцах, ийм төрлийн үйлдэл хийсэн этгээдэд хариуцлага тооцохгүй өнгөрөх зэргээс урьдчилан сэргийлэх чухал баталгаа болох ёстой. Цагдаагийн албан хаагчид, шоронгийн албан хаагчдыг хуурамчаар буруутгахаас уг тэмдэглэл мөн хамгаална.

95. Хорих ангид шинээр хүргэгдэн ирсэн бүх хоригдлуудыг хорих төвд ирснээс хойш аль болох яаралтай буюу 24 цагаас хэтрэхгүй хугацаанд эмнэлгийн үзлэгт оруулж үзлэгээс өмнө бий болсон ямар нэг гэмтлийн шинж тэмдэг бий эсэхийг шалгахын тулд биед бүхэлд нь үзлэг хийж байхыг ЭШУСДХ–ноос зүгээс зөвлөж байна. Уг үзлэгийн үр дүнгийн талаар зохих ёсоор, дэлгэрэнгүй байдлаар тусгайлан тогтоосон, нууц бүртгэлд бүртгэсэн байх ёстой.

96. Эмнэлгийн үзлэгийг тогтмол хийх ёстой бөгөөд эрүүл мэндийн байдлыг нууцлах зарчмын дагуу мэдээллийг хадгална: эмнэлгийн ажилтнаас өөр бусад хүнийг байлцуулахгүйгээр үзлэгийг хийх ёстой. Аюулгүй байдлыг хангах үүднээс, эсхүл цөөн тохиолдолд ийнхүү аюулгүй байдлаа хангуулахаар хүсэлт гаргаснаас бусад үед хүн харах, сонсох боломжгүй зайд хамгаалагчийг байлгана. Хэрэв аюулгүй байдлын урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай гэж үзвэл аюулгүй байдлыг хангах ажилтан ойр зайнд байрлах боломжтой.

97. Хорих ангиудад ажиллаж байгаа эмнэлгийн ажилтнуудын сургалтыг сайжруулах, Истанбулын протокол болон бусад холбогдох олон улсын стандартын талаар мэдлэг олгохыг Оролцогч улсад ЭШУСДХ–ноос зөвлөж байна.

### **Тусгай асуудлууд**

#### **Хорих ял эдлүүлэх албаны нэгдсэн эмнэлэг (401)**

98. Эмнэлгийн багаж хэрэгсэл, эм хомсдолтой байгаа талаар олон хоригдол гомдол мэдүүлсэн. Клиник эмнэлгүүдэд эмчлүүлэхийг зарим тохиолдолд хойшлуулдаг бөгөөд энэ нь шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж байхгүй, уг эмчилгээг хийлгэхийн тулд урьдчилж төлбөр хийхийг шаарддаг зэрэг бэрхшээл байдаг тухай мэдээлэл ЭШУСДХ хүлээн авсан.

99. Төлбөр, хураамж төлөх шаардлагатай эсэхийг нь үл харгалзан өвчтөнд зохих эмчилгээ хийж, эмнэлгийн хэрэгслээр хангах нь зүйтэй хэмээн ЭШУСДХ–ны зүгээс зөвлөж байна.

#### **Гадуур үйл ажиллагаа болон холбоо барих**

100. Хорих ял эдлүүлэх албаны нэгдсэн эмнэлэгт амралтын үйл ажиллагаа, гадуур дасгал хийлгэх зэрэг ажлууд огт хийгдэхгүй, хоригдлууд өдрийн турш өрөөндөө зүгээр сууж байгаа асуудлыг ЭШУСДХ авч үзэж байна. ЭШУСДХ–г газар дээр нь очиж танилцах үед өвчтөнүүдэд зориулсан ямар ч ном байхгүйг олж харсан. Өвчтөнүүд өөрсдийн өрөөнөөс гарахгүй байгаагийн зэрэгцээ хөдөөгийн дүр зургийг цонхоор харуулахгүйн тулд цонхонд цан татуулсан, эсхүл хөшиг татсан байсан. Эмчилгээний орчинд байх ёстой байдлыг шийтгэлийн зориулалтай болгосныг ЭШУСДХ–ны зүгээс шаардлагагүй гэж үзэж байна.

101. ЭШУСДХ–ны бүрэлдэхүүнд ирсэн мэдээллээр гадаад ертөнцтэй холбогдох, холбоо барихад хатуу хязгаарлалт тогтоож байна. Тухайлбал нээлттэй хорих ангид байгаа өвчтөнүүд сард ердөө 20 минут, хаалттай хорих ангид хоёр сар тутамд ердөө 20 минут тусгаар ярихыг зөвшөрч байна.

102. Дасгал хийлгэх, боловсролын, амралтын болон соёлын бусад арга хэмжээнд бүх өвчтөнүүдийг адил хэмжээнд оролцуулахыг ЭШУСДХ–ноос зөвлөж байна. Цонхонд тогтсон цаг яаралтай арилгах, гадаад ертөнцтэй холбогдох боломжийг нэмэгдүүлэх хэрэгтэй. Өвчтөнүүд хорих байранд буцаж очих үед эдлэх эрхтэй уулзалтын квотод эмнэлэгт байх үедээ бусадтай холбогдсон яриа, уулзалтыг оруулж тооцохгүй байх ёстой.

#### **Эмнэлгээс хорих анги руу шилжүүлэх**

103. Зарим өвчтөнүүд тэр дундаа хорих ял эдлүүлэх албаны нэгдсэн эмнэлэгт алслагдсан зайнд байрлах хорих ангиас ирж буй өвчтөнүүдийн эмчилгээ дуусч ял эдэлж буй хорих анги руу буцаан шилжүүлэхийн өмнө цагдан хорих 461 дүгээр төвд байрлаж байна. Өвчтөнүүдийн зүгээс гаргаж буй гомдолд тэдний эрүүл мэндийн байдалд сөргөөр нөлөөлхүйц, хэт олон хүн байрласан, эд зүйлийн хувьд тарчигхан нөхцөлд хоёр сар хүртэл хугацаанд байлгасан хэмээн дурдсан.

104. Өвчтөнүүдийн эмчилгээ дуусч ял эдэлж буй хорих анги руу буцаан шилжүүлэхийн өмнө цагдан хорих 461 дүгээр төвд байрлуулах хугацааг аль болох богино байлгах, ийнхүү байрлуулахдаа тэдгээр өвчтөний эрүүл мэндийн байдлыг дордуулахгүй нөхцөл байдалд байлгахыг ЭШУСДХ–ноос зөвлөж байна.

#### **Согтуурах, мансуурах донтой этгээдийг албадан эмчлэх, албадан хөдөлмөрлүүлэх газар**

##### **Эрх зүйн баталгаа, хамгаалалт**

105. Согтуурах, мансуурах донтой этгээдийг албадан байрлуулах эрх зүйн орчин тодорхой бус байна гэж ЭШУСДХ–ноос үзэж байна. Тодруулбал донтож байгаа бодисын талаар хийгдэж буй шинжилгээ нь өнгөцхөн, зохих анагаах ухааны сорилт, туршилтад тэр бүр үндэслэдэггүйд ЭШУСДХ анхаарал хандуулж байна. Албадан эмчлүүлж буй хүн бодит байдалд “донтогч, хамааралтай болсон” гэдгийг тодорхойлох нэмэлт эрүүл мэндийн үзлэг хийгдсэн талаар өвчтөний эрүүл мэндийн дэвтэрт дурьдсан нотолгоо байхгүй байгааг ЭШУСДХ олж тогтоов. Шүүхийн хэлэлцүүлэг болохоос өмнө бие махбодид эрүүл мэндийн үзлэг хийгээгүй, нийгэмд тогтсон тэднийг хорих ёстой гэж үздэг ойлголтоос арай дээр нөхцөлд буюу албадан байрлуулдаг гэж албадан эмчилгээнд хамрагдсан хүмүүс баталж байна.

106. Хоригдлуудын өгүүлж байгаагаар тэдний эдлэх эрхийн талаар ямар нэг тайлбар өгдөггүй, албадан байрлуулахтай холбоотой ямар ажиллагаа хийгддэг талаар тэдэнд тайлбарладаггүй. Тэднийг хорих буюу албадан байрлуулж байгаа шийдвэр нь шударга, тухайн цаг хугацаанд тохирсон, үр дүнтэй хяналт мөн эсэх талаар албадан хоригдсон хүмүүс мэдэхгүй байсан.

107. Эрх зүйн баталгаа, хамгаалалтын үндсийг тодорхойлоогүй тохиолдолд тус газар хүнийг байршуулах нь дур зоргоор хүнийг хорих боломжтой болгож байгаа хэмээн ЭШУСДХ–ны зүгээс үзэж байна.

108. ЭШУСДХ–ноос дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

а) Мансуурах бодис, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэдэг асуудалтай

хүмүүсийн хэрэгцээг олон нийтэд тулгуурласан арга зүйгээр авч үзвэл дур зоргоор аашлах эрсдлийг багасгахын тулд захиргааны журмаар хорих хэлбэрийн өөр нэг сонголт, хувилбарыг олж нээх шаардлагатай;

- b) Тухайн хүнийг “донтогч, хамааралтай болсон” гэж тодорхойлохоос өмнө зохих эрүүл мэндийн үзлэг, шалгуурт тулгуурласан байх шаардлагатай. Эрүүл мэндийн дэвтэрт бүх эрүүл мэндийн үзлэг хийсэн баримтыг нэг бүрчлэн тэмдэглэн үлдээх ёстой бөгөөд хоригдож буй этгээд болон түүний хуульчийн шаардсанаар мэдээллийг гаргаж өгөх;
- c) Эрх чөлөөг нь хязгаарласан бүх хүмүүс бодит байдал дээр албадлага хэрэглэснээс эхлэн эрх зүйн суурь баталгаа, хамгаалалтыг түүнд санал болгож буй эсэхийг Оролцогч улс нягтлах ёстой.
- d) Тус газар албадан байрлуулах шийдвэрийг бие даасан хяналт хийсний дараа зохих журмын дагуу биелүүлэн байрлуулах, түүнчлэн албадан байрлуулсан этгээд гомдол гаргах боломжийг бүрдүүлсэн давж заалдах механизмтай болох;

### **Албадан эмчлэх**

109. Албадан эмчлүүлж буй хүмүүстэй зүй бус харьцсан талаар ямар нэг гомдол ЭШУСДХ хүлээж аваагүй ч тэдний зөвшөөрөлгүйгээр донтолтын эсрэг албадан эмчилгээг тус газар хийж байгаа нь тодорхой байсан.

110. Согтуурах, мансуурах донтой этгээдийг албадан эмчлэх, албадан хөдөлмөрлүүлэх газарт ирсэн бүх этгээд эрүүл мэндийн үзлэгт тэр дундаа сэтгэцийн эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байхыг ЭШУСДХ-ноос зөвлөж байна. Зүй зохистой хэргийн менежмент болон өвчтөний эрүүл мэндийн нууц бүртгэлийн системийг бий болгож, бүх өвчтөнүүдийн мэдээллийг оруулах шаардлагатай. Өвчтөнд үзүүлж буй эмнэлгийн тусламж, үйлчилгээнд түүнээс зөвшөөрөл (free and informed consent) авсан эсэхийг өвчтөний эрүүл мэндийн дэвтэрт тусгах нь зүйтэй.

### **Эрүүл ахуйн нөхцөл**

111. Өвчтөнүүд байрлаж байгаа байрнаас тодорхой зайнд орших, гадна байрлаж буй (ил, далд нүхэн хэлбэрийн) жорлонгийн нөхцөл байдалд ЭШУСДХ анхаарал хандуулж байна. Усанд орох байр хэт хуучин байсны зэрэгцээ бараг хэрэглэх боломжгүй мэт байдалтай, цаашид хэрэгцээ хангахааргүй байсан.

112. Тус газарт байрлаж буй хоригдлуудад зориулагдсан байр, байгууламжийн эрүүл ахуйн нөхцөлийг нэн яаралтай сайжруулахыг мөн хангалттай гэрэл, зохих агааржуулалт бүхий эрүүл ахуйн шаардлага хангасан байрны дотор хэсэгт байрлах ариун цэврийн өрөө бүхий байгууламжийг бий болгох засвар хийхийг ЭШУСДХ зөвлөж байна.

## **VII. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв**

113. Бүрэлдэхүүний очиж танилцсан Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд сайн дурын үндсэн дээр эмчлүүлж буй хүмүүс, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дүнд эрх чөлөөг нь хязгаарласан өвчтөнүүд, эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны дүнд албадан эмчлүүлж буй сэтгэцийн эмгэгтэй хүн аль аль нь байна. Тус төвийн материаллаг нөхцлийг сайжруулсан засварын талаар ЭШУСДХ талархан тэмдэглэж байна. Олон нийтийн халамжийн системийг бий болгоход тодорхой алхамууд хийгдсэнийг мөн ЭШУСДХ сайшааж байна. Тус төвд зүй бусаар харьцаж буй талаар ямар нэг гомдол ЭШУСДХ хүлээн аваагүй болно.

114. Монгол Улс эмнэлэгт суурилсан сэтгэцийн эрүүл мэндийг эмчлэх тогтолцоо байгааг ЭШУСДХ онцлон тэмдэглэж байна. Олон нийтийн сэтгэцийн эрүүл мэндийн асуудалд анхаарал хандуулахыг дэмжих, эмнэлэгт суурилсан нөхцлөөс олон нийтийн халамжид суурилсан тогтолцоо руу шилжих шилжилтийг хөнгөвчлөхийн тулд сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагуудад зохих санхүүжилт хийх хэрэгцээ байсаар байна.

115. Сэтгэцийн эрүүл мэндийн салбарт зохих хэмжээний хүний нөөц, санхүүгийн нөөцийг хуваарилах нь зүйтэй хэмээн ЭШУСДХ зөвлөж байна. “Сайн дурын” үндсэн дээр гэж нэрлэгдэн эмчлүүлж буй хүмүүсийн эрхийг баталгаажуулахын тулд дотоодын хууль тогтоомжийг эргэн харах, зохих ёсоор хянадаг журам, процедур байгаа эсэхийг нягтлах шаардлагатай.

116. Олон нийтийн халамжийг хүртэж чадахгүй байгаагийн улмаас урт хугацаагаар эмнэлэгт хэвтэн эмнэлгийн үйлчилгээ, тусламж авч байгаа өвчтөнүүдэд тусламж хүртээх үүднээс олон нийтэд суурилсан үйлчилгээг бий болгохыг дэмжих нэмэлт арга хэмжээ авахыг ЭШУСДХ зөвлөж байна.

117. Эрүүл мэндийн ажилтнуудыг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай конвенц зэрэг хүний эрхийн олон улсын стандартуудын талаар мэдлэг олгох сургалтуудад хамруулахыг ЭШУСДХ зөвлөж байна. Түүнчлэн сэтгэл мэдрэлийн эмч, сувиллагч, сэтгэл зүйч, нарийн мэргэжлийн эмч, нийгмийн ажилтан зэргийн тоог нэмэгдүүлэх шаардлага байна. Өвчтөнүүдэд олон талын халамж үзүүлэхийн зэрэгцээ нөхөн сэргээх, мэргэжлийн, амралт чөлөөт цагийн үйл ажиллагааг санал болгох нь зүйтэй.

### **Албадан байршуулах, хууль эрх зүйн хамгаалалт, албадлагын арга хэмжээ**

118. Сэтгэцийн эрүүл мэндийн төвд албадан байршуулах асуудлыг 2013 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр батлагдсан Сэтгэцийн эрүүл мэндийн тухай Монгол Улсын хуулийн Тавдугаар бүлгээр зохицуулдаг байна. Албадан байршуулах ажиллагааны гол зорилго нь эмнэлэгт хэвтэж эмчлүүлэхэд түүний зөвшөөрлийг огт авахгүй нөхцөл байдалд байгаа өвчтөнүүдийг хамгаалах явдал юм. Хэдий ийм боловч тус хуулиар албадан байршуулах болон сайн дураараа эмчлүүлэх хоёр тусдаа асуудлын зааг ялгааг гаргаж өгөөгүй гэж ЭШУСДХ үзэж байна. Түүнчлэн өвчтөнүүдийн хувьд түүнд хийх эмчилгээний талаар мэдээлэл өгч, зөвшөөрөл авах хэрэгцээтэй эсэх талаар тусгайлсан зохицуулалтгүй. Албадан эмчлүүлэх асуудлаар шийдвэр гаргахад шүүх эрх мэдлийн

байгууллага оролцохгүй байгаа бөгөөд өөр хөндлөнгийн хяналтын механизм байхгүй байна.

119. Эмнэлгийн ажилтнууд нь өвчтөнүүдээс тэднийг албадан байршуулсан асуудал болон тэдгээрийн эмчилгээний асуудлаар (free and informed consent) зөвшөөрөл авах системтэй арга замыг эрэлхийлэхийг SPT-ийн зүгээс зөвлөж байна.

120. Албадан эмчилгээ цаашид хийлгэх шаардлагагүй болсон өвчтөнүүдийн хувьд эрх чөлөөтэй байх эрхийг нь хангахын тулд албадан эмчлэх байгууллагад байгаа хүмүүсийн нөхцөл байдлын талаар байнгын шалгалт явуулж байгаа эсэхийг нягтлах арга хэмжээ авч байхыг ЭШУСДХ зөвлөж байна.

121. Өвчтөнүүдийн эрхийг хамгаалах, мөн сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагад байршуулах боловч өвчтөний өөрийн зөвшөөрөлгүйгээр эмчилгээ хийж болохгүй онцгой тохиолдлуудыг тодорхой зохицуулсан нарийн шалгууруудыг агуулсан хууль тогтоомжийг Орлоцогч улс батлахыг ЭШУСДХ зөвлөж байна.

122. Хязгаарлалтуудыг зөвхөн эцсийн арга хэмжээ болгож ашиглах ёстой бөгөөд шийтгэл хэлбэрээр огт ашиглахгүй байх, бодит эрсдлийг хянах өөр боломжит хэрэгсэл байхгүй байгаа нөхцөлд гагцхүү хэрэглэх, ийнхүү хэрэглэсэн тохиолдолд аль болох богино хугацаанд хэрэглэх хязгаарлалтыг даруй зогсоох ёстой гэдгийг ЭШУСДХ онцлон тэмдэглэж байна.

123. Сайн дураар эмчлүүлж байгаа өвчтөнүүд өөрсдийн хүсэл зоригийн эсрэг эрх чөлөөгөө хязгаарлуулах ёсгүй гэдгийг ЭШУСДХ зөвлөж байна. Хэрэв эрхийг хязгаарлан албадах арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай бол уг зорилгод нийцсэн тусгайлан тогтоосон газарт тус арга хэмжээг авах ёстой бөгөөд эрхийг нь хязгаарласан өвчтнүүдэд зохих хувцас өмсүүлэх, бусад өвчтнүүдэд харагдахгүй байхаар байрлуулах шаардлагатай. Уг арга хэмжээ авахад оролцож байгаа ажилтнуудыг зохих ёсоор сургалтад хамруулж бэлтгэх хэрэгтэй бөгөөд албадан арга хэмжээ авч байх үед бусад өвчтөнүүдээс туслалцаа авах ёсгүй; өвчтөний эрүүл мэндэд аюул учруулахгүй байх, шаардлагагүй өвдөлтийг бий болгохгүй байхын тулд тус арга хэмжээг авахад тусгай ур чадвар, халамж шаардагддаг.

124. Бодит арга хэмжээ юу байх, ямар хугацаагаар уг арга хэмжээг хэрэглэх; ямар нөхцөл байдалд хэрэглэх; уг арга хэмжээг хэрэглэхийн өмнө болон уг арга хэмжээ авсны дараа ямар зөвшөөрлийн, хяналтын тогтолцоо байх ёстой; уг арга хэмжээ авч дууссаны дараа ямар процесс ажиллагаа явагдах ёстой; ерөөс ямар нөхцөлд хязгаарлан албадах арга хэмжээг хэрэглэж болохыг зохицуулсны дагуу албадлагын арга хэмжээг ашиглах талаар цогц, нягт нямбай бодлого боловсруулан батлахыг Монгол улсад ЭШУСДХ-ноос зөвлөж байна. Албадлага, хязгаарлалтыг хэрэглэсэн бүх тохиолдлыг тусгай бүртгэлд тэмдэглэн үлдээх ёстой, гомдол гаргах механизм тухайн тогтолцоон дотор, өөр байдлаар уг тогтолцооноос гадна гомдолыг хүлээж авдаг байх шаардлагатай.

### **VIII. Дараагийн шатанд авах арга хэмжээ**

125. Женев дэх Монголын байнгын төлөөлөгчид тус Тайланг дамжуулан өгснөөс хойш зургаан сарын дотор тайланд хариу ирүүлэхийг ЭШУСДХ шаардаж байна. Өгсөн зөвлөмжүүдэд шууд хариулах, тус Тайланд дурдсан мэдээллүүдийн талаар хариу ямар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн, мэдээллийн мөрөөр асуудлыг шийдвэрлэн

хэрэгжүүлэх ямар арга хэмжээ авахаар төлөвлөж байгаа (төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацааг тодорхойлсон байх)–г тусгана. Түүнчлэн тухайн нэг зөвлөмжийг хэрэгжүүлэх байгууллагыг нарийвчлан заах, ерөнхий бодлогын чанартай, практик чанартай анхаарал хандуулахыг хүссэн зүйлсийг хариуцан ажиллах байгууллагыг зааж өгнө.

126. ЭШУСДХ–той холбоотой байгаа этгээд, эсхүл холбогдохыг хүсч байгаа этгээдийн талаар ямар нэг эх сурвалжаар олж мэдэн, түүнд аливаа хэлбэрийн шийтгэл, эсхүл хариу арга хэмжээ авахыг Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн 15 дугаар зүйлээр хориглосон. Ийм төрлийн шийтгэл, хариу арга хэмжээ авахгүй байхыг нягтлах үүрэг хүлээж байгаа Монгол улсад ЭШУСДХ зүгээс сануулж байна. Мөн өөрийн ирүүлэх тайланд уг үүргийг биелүүлэхийн тулд ямар арга хэмжээ авах гэж байгаа дараагийн алхамуудын талаар нарийвчилсан мэдээлэл ирүүлэхийг шаардаж байна.

127. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нь байнга үргэлжилсэн, өргөн хүрээг хамарсан үүрэг байдгийг ЭШУСДХ–ноос эргэн сануулж байна. Нэмэлт Протоколын дагуу хүлээсэн үүргээ Монгол Улс хэрэгжүүлэхэд үргэжлүүлэн туслалцаа авахын тулд ЭШУСДХ–г идэвхижүүлэх үүднээс эрх чөлөөг нь хязгаарласан хүнтэй харьцах болон Үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг бий болгох гэсэн энэ хоёр асуудалд хамаарах аливаа хууль, эрх зүйн, зохицуулалтын, бодлогын болон бусад холбогдох хөгжлийн асуудлаар мэдээлэл өгөх шаардлагатай байна.

128. Айлчлал болон энэхүү Тайлан нь яриа хэлэлцээний нэгэн хэсэгт тооцогдож байгаа гэж ЭШУСДХ үзэж байна. Эрх чөлөөг хязгаарлан байрлуулдаг газруудад эрүү шүүлт тулгах, зүй бусаар харьцах байдлаас урьдчилан сэргийлэх нийтлэг зорилгод хүрэхийн тулд Нэмэлт Протоколын дагуу ЭШУСДХ–ны зүгээс техникийн туслалцаа, зөвлөгөө үзүүлэх, цаашид зөвлөмж өгөх зэргээр Монгол Улс өөрийн хүлээсэн үүргийг биелүүлэхэд ЭШУСДХ туслах болно. Тус яриа хэлэлцээг боловсронгуй болгох хамгийн үр дүнтэй, үр ашигтай арга зам бол ЭШУСДХ өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий үндэсний эрх бүхий байгууллагууд, албан тушаалтнуудтай уулзан энэхүү тайлангийн хариуг зургаан сарын дотор бэлтгэн ирүүлнэ гэдэгт ЭШУСДХ найдаж байна.

129. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн 11 дүгээр зүйлийн дагуу ЭШУСДХ болон монголын эрх бүхий байгууллагууд хоорондын яриа хэлэлцээрийн гол агуулга нь ЭШУСДХ–ноос өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэхэд чиглэж байсан тул тус тайланд өгөх хариуг 6 сарын хугацаанд ирүүлэхийг ЭШУСДХ зөвлөж байна. Энэ тайлангийн хариуг ирүүлэх үед Монгол улс ЭШУСДХ–той яриа хэлэлцээр өрнүүлэх санаачлага гаргахыг ЭШУСДХ нэмж зөвлөж байна.



**7.6 ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ,  
ХҮНЛЭГ БУСААР БУЮУ ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРМЖЛОН ХАРЬЦАЖ  
ШИЙТГЭХИЙН ЭСРЭГ АСУУДАЛ ХАРИУЦСАН ХОРООНД МОНГОЛ УЛСААС  
КОНВЕНЦИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР ХҮРГҮҮЛЭХ ЭЭЛЖИТ ГУРАВ ДАХЬ  
УДААГИЙН ТАЙЛАН (2020 ОН)**

1. Монгол Улс нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг асуудал хариуцсан Хорооноос тус улсын 2 дахь ээлжит тайланд хийсэн дүгнэлтийн 44 дэх хэсэгт заасны дагуу энэ удаагийн ээлжит тайланг боловсруулан, хүргүүлж байна.

2. Тус тайланд Конвенцийн 19 дүгээр зүйлийн 1–д заасны дагуу конвенцийн 1–16 дугаар зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн талаарх мэдээлэл, мөн Хорооноос өгсөн ажиглалт, дүгнэлтэд өгөх хариултуудыг оруулсан.

3. Зүйл тус бүрээр оруулсан мэдээллүүд нь тайлант хугацаа буюу 2017 оноос 2020 оны эхний гурван улирлын байдлаар шинэчилсэн мэдээлэл болно.

4. Конвенцийн хэрэгжилттэй холбогдуулан гарсан дэвшил, бусад арга хэмжээний талаарх ерөнхий мэдээлэл, конвенцийн хэрэгжилтийг хангах үүднээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон Хорооноос өгсөн дүгнэлт, зөвлөмжид өгөх хариулт, Хорооноос шаардсан нэмэлт мэдээллүүдийг тайланд тусгалаа.

## **I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

5. Конвенцийн Хороотой хийсэн яриа хэлэлцээ, түүнээс өгсөн дүгнэлт, зөвлөмжүүд нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг олон улсын конвенцийг хэрэгжүүлэхэд үндэслэлтэй, бодитой үр нөлөө үзүүлж байна.

6. Үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг бий болгох, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх Дэд хороотой хамтран ажиллаж байгаад тус улсын зүгээс талархаж байна.

7. Парисын зарчмуудад нийцүүлж, хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг үндэсний байгууллагын хараат бус байдал, гишүүнд тавих шаардлага, нэр дэвшүүлэх, томилохтой холбоотой зохицуулалтыг сайжруулсан Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 23–ны өдөр баталлаа.

8. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнтэй болох эрх зүйн үндэслэлийг дээрх хуулиар бий болгов. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд дэмжлэг үзүүлэн ажиллах нэгжийн чиг үүргийг хуульд тусгасан.

9. Аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл эрх чөлөөг нь хязгаарлан байлгадаг буюу тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй газруудад тухайлбал хорих байгууллага, цагдан хорих анги, баривчлах байр /төв/, түр болон албадан саатуулах газар, хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон ахмадын асрамжийн газар, сургуулийн дотуур байр, албадан эмчилгээний байр, цэргийн сахилгын байр, хилийн шалган нэвтрүүлэх боомт дахь түр саатуулах байр, сэтгэцийн эмнэлэг зэрэгт хэдийд ч саадгүй нэвтрэх, хяналт шинжилгээ хийх, нөхцөл байдлыг техник хэрэгсэл ашиглан баримтжуулах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулахаар шилжүүлж, олон нийтэд мэдээлэх үүргийг эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн хүлээх юм.

10. Хүний эрхийн үндэсний комиссын гишүүд тэр дундаа эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний сонгон шалгаруулалтын томилгооны сонсголыг<sup>6</sup> анх удаа цахимаар зохион байгуулж, олон нийтийн<sup>7</sup> оролцоог бүрэн хангалаа.

11. Тайлангийн хугацаанд Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн бодлогын хүрээнд хэд хэдэн суурь хуулийг шинэчлэн найруулж баталлаа. Тухайлбал Эрүүгийн хуулийг 2015 онд, Төрийн албаны тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Прокурорын тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Цагдаагийн албаны тухай хуулийг 2017 онд, Өмгөөллийн тухай хуулийг 2019 онд, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2020 онд тус тус баталлаа.

## II. АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ БОЛОН ХОРООНООС ӨГСӨН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖИД ӨГӨХ ХАРИУЛТ

### 1 дүгээр зүйл болон 4 дүгээр зүйл

#### Эрүүдэн шүүх хэлбэрүүд, түүнд оногдуулах шийтгэлүүд

2. Хорооны өмнөх ажиглалт дүгнэлт (9 болон 10 дахь заалт)-д зааснаар дараах асуудлаар мэдээлэл ирүүлнэ үү.

2-(а) Эрүүгийн хуульд эрүү шүүлт тулгахыг бие даасан гэмт хэрэгт тооцсон эсэх;

12. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг 2002 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйлд бие даасан гэмт хэрэг болгон анх хуульчилсан. 2015 онд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг батлахдаа “Эрүү шүүлт тулгах” гэмт хэргийг тус хуулийн 21.12 дугаар зүйлд тусгасан. 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс тус хууль хүчин төгөлдөр үйлчилж байна.

13. Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлийн 1-д “Төрийн алба хаагч тайлбар мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял шийтгэл оногдуулах зорилгоор өөрөө эсхүл бусад этгээдийг хатгаж, зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар тухайн үйлдлийг хийхийг

<sup>6</sup> Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан Ажлын хэсэг уг ажлыг зохион байгуулсан.

<sup>7</sup> <http://parliament.mn/n/odcy> – сүүлд нэвтэрсэн 2020 оны 06 дугаар сарын 11-ний өдөр

зөвшөөрч байгаагаа илэрхийлж бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж тодорхойлсон<sup>8</sup>.

*2-(b) Эрүүгийн хуульд эрүү шүүлтийн тодорхойлолт орсон эсэх, хэрэв тодорхойлолт оруулсан бол Конвенцийн 1 дүгээр зүйлд заасан тодорхойлолттой нийцэж буй эсэх, уг тодорхойлолтод заагдсан үйлдлүүд нь аливаа ялгаварлан гадуурхалт, алагчлалд үндэслээгүй, хүчирхийлэл, айлгаж сүрдүүлэх аливаа үйлдэл агуулаагүй, гуравдагч этгээдийн эсрэг чиглээгүй байгаа эсэх шинжийг тодорхойлсон эсэхийг нягтлах;*

14. Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлийн<sup>9</sup> 4–т тус хуулийн нэр томьёо, ухагдахууныг тайлбарлахад Монгол Улсын хууль, Монгол Улсын хуулиар соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан тодорхойлолт, хэм хэмжээг баримтална гэж заасан. Эрүүгийн хуульд эрүү шүүлт тулгах гэмт хэргийг томьёолохдоо Конвенцийн 1 дүгээр зүйлд заасан тодорхойлолттой<sup>10</sup> нийцүүлсэн.

15. 2002 оны 09 дүгээр сарын 01–ний өдрөөс 2017 оны 07 дугаар сарын 01–ний хооронд үйлчилсэн Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйлийн 251.1–д гэмт хэргийн шинжийг тодорхойлохдоо хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, тарчилган зовоох, тохуурхан даажигнах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэж мэдүүлэг өгөхийг албадан эрүү шүүлт тулгасан байх гэсэн элементийг заасан. Тус зүйлийн 251.2 дахь хэсэгт “энэ хэргийн улмаас хүний бие махбодид хүндэвтэр, хүнд гэмтэл, их хэмжээний хохирол учирсан” байх элементийг тодорхойлсон. Мөн зүйлийн 251.3–т “энэ хэргийн улмаас хохирогч нас барсан” гэсэн элементийг нэмж тодорхойлсон.

16. 2017 оны 07 дугаар сарын 01–ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд “Эрүү шүүлт тулгах” гэмт хэргийг хуульчлан өгсөн. Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлийн 1–д “... тайлбар мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял шийтгэл оногдуулах зорилгоор өөрөө эсхүл бусад этгээдийг хатгаж, зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрч байгаагаа илэрхийлж бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон ...” гэж тодорхойлсон нь Конвенцийн 1 дүгээр зүйлд заасан “эрүүдэн шүүх” гэж хэн нэг хүн буюу гурав дахь этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гурав дахь этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх айлгах, айлган сүрдүүлэх шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчилах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт,

---

<sup>8</sup> <https://www.legalinfo.mn/law/details/11634?lawid=11634>– сүүлд нэвтэрсэн 2020 оны 05 дугаар сарын 18–ны өдөр

<sup>9</sup> 1.2 дугаар зүйл– Хууль ёсны зарчим

<sup>10</sup> “эрүүдэн шүүх” гэж хэн нэг хүн буюу гурав дахь этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гурав дахь этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх айлгах, айлган сүрдүүлэх шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчилах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийн бие махбод, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг хэлнэ” (Төрийн мэдээлэл, Тусгай дугаар, Боть 1, УБ, 2004), <https://www.legalinfo.mn/law/details/1289?lawid=1289> сүүлд нэвтэрсэн 2020 оны 05 дугаар сарын 18–ны өдөр

ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гуравдагч этгээдийн бие махбод, сэтгэл санааг шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг хэлнэ” гэсэнтэй нийцэж байна.

17. 2002 оны Эрүүгийн хуульд зөвхөн “хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч” дээрх гэмт хэргийг үйлдэх субъект байсныг “төрийн албан хаагч” болгон субъектыг өргөжүүлсэн. Түүнчлэн уг гэмт хэргийг тодорхойлж байгаа үйлдлүүд нь аливаа ялгаварлан гадуурхалт, алагчлалд үндэслээгүй, хүчирхийлэл, айлгаж сүрдүүлэх аливаа үйлдэл агуулаагүй, гуравдагч этгээдийн эсрэг чиглээгүй болно.

*2–(с) Конвенцийн 4 (2)зүйлд заасны дагуу гэмт хэргийн ноцтой эсэхээс хамаарч ял шийтгэлийг ялгавартай оногдуулахаар эрүү шүүлт хийсэн гэмт үйлдлийг эрүүгийн хуульд тодорхойлсон эсэх, ял шийтгэлийн дээд хугацаа нь таван жилийн хугацаатай хэрэглэгдэж байгаа нь хэвээр эсэх;<sup>11</sup>*

18. Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хэргийн нөхцөл байдал, ноцтой эсэхээс хамаарч ял шийтгэлийг ялгавартай оногдуулах шударга ёсны зарчмыг хуульчилсан. Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 1–д “эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна” гэж заасан.

19. Эрүүгийн хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2–т зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг тал бүрээс нь харгалзан үзэхээр тусгасан.

20. Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд заасан эрүү шүүлт тулгах гэмт хэрэг үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр хуульчилсан.

21. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн улмаас хүний амьд явах эрх, хүний эрүүл мэндийн халдашгүй байдал зөрчигдсөн тохиолдолд Эрүүгийн хуулийн тодорхой зүйл, хэсгээр давхар зүйлчилж, хариуцлага хүлээлгэж байна. Энэ тохиолдолд эрүүдэн шүүж, хүнлэг зүй бусаар харьцсан нь хүндрүүлэх нөхцөл болох бөгөөд хүлээлгэх ялын дээд хэмжээ өөрчлөгдөнө.

22. Амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг болох “Хүнийг алах” гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 1–д зүйлчилсэн. Тус зүйлд зааснаар хүнийг алсан бол найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Үүн дээр 10.1 дүгээр зүйлийн 2.12 дахь заалтад заасан “эрүүдэн шүүж”<sup>12</sup> хүнийг алсан тохиолдолд хүндрүүлэх нөхцөлөөр давхар зүйлчилнэ. Энэ тохиолдолд арван хоёроос хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар нь хорих ял оногдуулна.

23. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг болох “Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах” гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 11.1 дүгээр

<sup>11</sup> ССРР/С/МНГ/СО/6, 21 дэх хэсэг.

<sup>12</sup> Эрүүгийн хуулийн 11.1 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсэг “энэ хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн;”

зүйлд зааж өгсөн. Тус зүйлийн 1–д зааснаар уг хэргийг үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Энэ гэмт хэргийг “хохирогчийг тохуурхан доромжилж үйлдсэн”<sup>13</sup>, эсхүл “бие махбодын, сэтгэл санааны шаналал, зовиур үүсгэж үйлдсэн”<sup>14</sup> бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Эрүүгийн хуулийн 11.4 дүгээр зүйлийн 2.1–д заасан хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах гэмт хэргийг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар<sup>15</sup> үйлдсэн бол, мөн 11.4 дүгээр зүйлийн 2.3–т заасан бие махбодын, сэтгэл санааны шаналал, зовиур үүсгэж үйлдсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

24. Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйлд “Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах” гэмт хэргийг хуульчилсан. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах үедээ зүй бус харьцсан, эрүүдэн шүүсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэхээр заасан.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд заасан эрүү шүүлт тулгах гэмт хэрэг болон тус хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2.12 эрүүдэн шүүж хүнийг алах гэмт хэрэгт ногдуулах ял хоорондоо зөрүүтэй байгаа нь гэмт хэргийн ноцтой эсэхээс хамаарч ял шийтгэлийг ялгамжтай тодорхойлоход чухал ач холбогдолтой, оновчтой зохицуулалт болсон.

*2–(d) Эрүүдэн шүүх гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй гэдгийг нягтлах талаар авсан арга хэмжээнүүд.*

25. 2002 оны Эрүүгийн хуулиар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн (хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд) ангилалаас хамааруулан тоолдог байсныг Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар өөрчлөн ялын доод болон дээд хэмжээнээс хамааруулан ялгамжтай байдлаар тоолохоор зохицуулсан нь эрх зүйн шинэчлэлийн хүрээнд гаргасан дэвшил юм. Тухайлбал Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд заасан эрүү шүүлт тулгах гэмт хэрэг үйлдсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх тул энэ тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг тоолно.<sup>16</sup> Харин тухайн гэмт хэрэгт бүх насаар

---

<sup>13</sup> Эрүүгийн хуулийн 11.1 дүгээр зүйлийн 2.2 дахь хэсэг

<sup>14</sup> Эрүүгийн хуулийн 11.1 дүгээр зүйлийн 2.3 дахь хэсэг

<sup>15</sup> Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар

<sup>16</sup> Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон ... гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн бол яллагдагчаар татаж болохгүй гэж тус хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт заасан.

нь хорих ял оногдуулахаар заасан тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй байх хэм хэмжээг хуульчилсан.

26. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 4–т “Энэ хуульд бүх насаар хорих ял оногдуулахаар заасан ... гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй” гэж заасан. Үүний дагуу Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2.12 дахь заалтад зааснаар хүнийг “эрүүдэн шүүж” алсан бол ... бүх насаар нь хорих ял оногдуулахаар заасан тул энэ тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй.

27. Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг боловсронгуй болгох чиг үүрэгтэй Ажлын хэсэг Хуульзүй, дотоод хэргийн яаманд ажиллаж байна. Тус Ажлын хэсгээс санаачлан боловсруулсан Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг удахгүй Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ. Хуулийн төсөлд орсон зарим тодорхой саналуудаас дурдвал Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд заасан эрүү шүүлт тулгах гэмтхэрэгт оногдуулах ялыг тэнсэх боломжгүй байхаар ял хариуцлагыг чангатгах, хөөн хэлэлцэх хугацааг тооцохгүй байхыг, “зүй бус харьцаа”–г “эрүү шүүлт”–ээс ялгаж элементийг тодорхойлох зэрэг болно.

## **2 дугаар зүйл**

### **Эрх зүйн үндсэн хамгаалалт**

*3. Хорооноос өмнө өгсөн зөвлөмжийн (11 болон 12 дахь параграф) дагуу дараах мэдээллийг шинэчлэн гаргаж өгнө үү.*

*3-(а)-1 Хоригдсон хүмүүсийн хувьд эрх чөлөөг нь хязгаарлахтай холбоотойгоор суурь эрх зүйн баталгаагаар бодит байдал дээр хангаж байгаа эсэх;*

28. Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль, Хорих байрны дотоод журам, “Баривчлах байрны дотоод журам”, Хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, түүнийг эрүүл мэндийн байгууллагад эмчлэх, цагдан хорих байранд эмнэлгийн мэргэжилтэн ирж үйлчлэх журмаар хоригдсон хүмүүсийн суурь эрх зүйн баталгаа бодит байдал дээр хангагдаж байна.

29. Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 3–т “Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ” гэж хуульчилсан.

30. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Баривчлагдсан, цагдан хоригдсон этгээд нь тус хуулиар хязгаарласнаас бусад Монгол Улсын иргэний эрх, эрх чөлөө эдэлж, үүрэг хүлээнэ” гэж заасан.

31. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалтад “Хоригдсон этгээд нь өмгөөлөгчтэй уулзах, хууль зүйн туслалцаа авах эрх эдэлнэ” гэх мөн “Хорих байрны дотоод журам”–ын 19.1

дэх хэсэгт “Хоригдсон этгээд нь өөрийн хүссэн үедээ сонгон авсан өмгөөлөгчөөрөө өмгөөлүүлэх эрхтэй” гэх заалтуудын дагуу хоригдсон этгээдийг өмгөөлөгчтэй уулзаж, хууль зүйн туслалцаа авах боломж, нөхцөлөөр ханган ажиллаж байна.

32. Хэрэв хоригдсон этгээд нь төлбөрийн чадваргүй бол “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай” хуулийн дагуу тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хэрэгжүүлэх зорилгоор улсын өмгөөлөгч албан томилолтын дагуу хууль зүйн зөвлөгөө болон өмгөөллийн үйлчилгээг үзүүлж байна.

33. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 17.1.10 дахь хэсэгт “Хоригдсон этгээд нь эмнэлгийн тусламжийг Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд<sup>17</sup> заасан журмын дагуу авах эрх эдэлнэ” гэж заасан байна.

*3–(а)–2 хуульд тодорхойлон заасан эрхүүдээр хангагдаж байгаа байдал буюу тэр дундаа ямар хэрэгт буруутгагдаж байгааг нь амаар болон бичгээр түүнд мэдэгдэх, хуульчтай байх, шүүхийн шийдвэрийг танилцуулахаас өмнө сэжигтнийг цагдан хорьсон тохиолдолд<sup>18</sup> мөн дээрх эрхүүдийг хангах, хэрэв төлбөрийн чадваргүй хүн бол хууль зүйн туслалцаа үзүүлдэг эсэх, байцаалтын явцад өмгөөлөгчтэй байх эрх, эрхийг нь хязгаарласан даруй шүүгчийн өмнө авчирч эрх хязгаарласан нь хууль ёсны эсэх асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэх;*

34. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Энэ зүйлийн 1.1<sup>19</sup> дэх заалтад зааснаас бусад үндэслэлээр хүнийг саатуулсан бол хаана байгаа талаар түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, төрөл, садангийн хүн, өмгөөлөгчийн хэн нэгэнд, эсхүл түүний мэдэгдэхийг хүссэн хүнд 8 цагийн дотор мэдэгдэнэ.” гэж заасан. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу өсвөр насны сэжигтэн, яллагдагчийг албадан ирүүлсэн, баривчилсан, цагдан хорьсон тухай түүний гэр бүлийн гишүүн, хууль ёсны төлөөлөгч, эсхүл өмгөөлөгчид нь 6 цагийн дотор мэдэгдэнэ.

35. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Сэжигтэнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол танилцуулсны дараа энэ хуулийн Долдугаар бүлэгт заасан яллагдагчийн эрхийг тайлбарлан өгч, тэр тухай тэмдэглэлд тусгаж, гарын үсэг зуруулна” гэж заасан.

36. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар хүнийг баривчлах үед түүнд баривчилсан шалтгаан, үндэслэлийг мэдэгдэж, өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, шүүхэд гомдол гаргах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг сануулна.

37. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Хөдөлмөр, нийгмийн

---

<sup>17</sup> 2015 онд шинэчилсэн найруулгаар батлагдсан.

<sup>18</sup> CAT/C/MNG/CO/2/Add.1, 10 дахь хэсэг.

<sup>19</sup> 1.1. тагнуулын болон цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч, хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч холбогдогчийг хэн болохыг тогтоох зорилгоор 6 цаг хүртэл хугацаагаар /ЗШШГХ–ийн 5.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалт/

хамгааллын сайдын 2017 оны хамтарсан А51/А69 дугаар тушаалаар баталсан. Тус журмын 5.1.3-т заасны дагуу Хороо нь хууль зөрчсөн хүүхдийн мэдээллийг цагдаагийн байгууллага болон бусад этгээдээс хүлээн авсны дараа нэн даруй хууль зөрчсөн хүүхэд болон түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчтэй уулзах уулзалтыг зохион байгуулна.

38. (Тайлангийн 32 дахь хэсгийг үзнэ үү.) Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо цагдаагийн байгууллага болон бусад этгээдээс хүүхдийн мэдээллийг авсны дараа тухайн насанд хүрээгүй хүн өмгөөлөгчөө сонго хболомжгүй, өмгөөлөгч авах төлбөрийн чадваргүй нь тогтоогдвол Монголын хуульчдын холбоо болон бусад холбогдох байгууллагад хандан өмгөөлөгчөө сонгох эсвэл томилуулах, Хууль зүйн туслалцааны төвд хандан улсын өмгөөлөгч авах боломжоор хангана.

39. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.6 дугаар зүйлийн 1<sup>20</sup> дэх хэсэгт зааснаар мөрдөгч нь баривчлагдсан сэжигтэнд баривчлах тухай шүүхийн шийдвэр танилцуулахаас өмнө, эсхүл шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан бол баривчилсан даруйд түүнд ямар гэмт хэрэгт сэжиглэж байгаа, хууль зүйн туслалцаа авах эрхтэй болох, түүний хийсэн үйлдэл, хэлсэн үг өөрийнх нь эсрэг шүүхэд нотлох баримт болохыг анхааруулах болон хууль ёсны шаардлагыг биелүүлэхгүй бол холбогдох хуульд заасны дагуу албадлага хэрэглэхийг сануулах зэргийг танилцуулна.

40. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.3 дугаар зүйлд “Ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх” гэсэн зохицуулалт бий. Тус зүйлийн 1 дэх хэсэгт “Яллагдагч ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх эрхтэй”, 2 дахь хэсэгт “Яллагдагчаар татсан, таслан сэргийлэх арга хэмжээ авсан шийдвэртэй танилцах эрхтэй” гэж тус тус заасан.

*3-(a)-3 шүүхэд гомдол гаргах эрх;*

41. Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 14-т “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно” гэж заасан.

<sup>20</sup> 31.6 дугаар зүйл. Баривчилсны дараа хийгдэх ажиллагаа

1. Мөрдөгч баривчлагдсан сэжигтэнд баривчлах тухай шүүхийн шийдвэр танилцуулахаас өмнө, шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан бол баривчилсан даруй түүнд дараахь зүйлийг танилцуулна:

1.1. ямар гэмт хэрэгт сэжиглэж байгаа;

1.2. хууль зүйн туслалцаа авах эрхтэй болох;

1.3. түүний хийсэн үйлдэл, хэлсэн үг өөрийнх нь эсрэг шүүхэд нотлох баримт болохыг анхааруулах;

1.4. хууль ёсны шаардлагыг биелүүлэхгүй бол холбогдох хуульд заасны дагуу албадлага хэрэглэхийг сануулах.



42. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.7 дугаар зүйлийн 1-т “Баривчлагдсан сэжигтэн, цагдан хоригдсон яллагдагч, шүүгдэгч нь түүнийг баривчилсан, цагдан хорьсон нь хууль ёсны эсэхийг шүүхээр хянуулах, хууль бусаар баривчилсан, цагдан хорьсон бол суллуулахаар шүүхэд гомдол гаргах эрхтэй” гэж заасан байна.

43. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.17 дахь заалтад “Хоригдсон этгээд нь өөрт холбогдох асуудлаар болон хорих байрны нөхцөл, журам, үйл ажиллагааны талаар аль ч байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол, хүсэлт гаргах эрхтэй” гэж хуульчилсан.

*3-(а)-4 гэр бүлийн гишүүн, эсхүл эрх нь хязгаарлагдсан хүний сонгосон аливаа бусад хүнд түүнийг цагдан хорьсон талаар даруй мэдэгдэх;*

44. Баривчилсны дараа хийгдэх ажиллагаа буюу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.6 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар мөрдөгч сэжигтнийг баривчилснаас хойш 6 цагийн дотор тухайн сэжигтнийг баривчилсан талаар түүний гэр бүлийн арван найман насанд хүрсэн гишүүн, эсхүл өмгөөлөгч, гадаад улсын иргэн бол тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газарт мэдэгдэнэ.

45. Өсвөр насны сэжигтэн, яллагдагчийг албадан ирүүлсэн, баривчилсан, цагдан хорьсон тухай түүний гэр бүлийн гишүүн, хууль ёсны төлөөлөгч, эсхүл өмгөөлөгчид нь 6 цагийн дотор мэдэгдэхээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан.

46. Яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотойгоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.13 дугаар зүйлийн 10.1-т “яллагдагчийг цагдан хорих шийдвэр гаргаснаас хойш 2 цагийн дотор яллагдагчийг цагдан хорьсон талаар түүний гэр бүлийн арван найман насанд хүрсэн гишүүн, эсхүл өмгөөлөгч, гадаад улсын иргэн бол тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газарт, тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газар байхгүй бол гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэнэ” гэж хуульчилсан.

47. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2014 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 209 дүгээр тушаалаар батлагдсан “Хорих байрны дотоод журам”-ын 2.11 дэх хэсэгт “Хоригдох этгээдийг хүлээн авсан тухай лавлагааг жижүүрийн туслах хөтлөх бөгөөд ... лавлагаанд уг этгээдийг баривчлах, хорих болсон шалтгаан, цагдан хорих гэж байгаа газрын талаар түүний ар гэрийнхэн, төрөл садан болон өмгөөлөгчид нь албан ёсоор мэдэгдсэн эсэх талаар лавлаж тэмдэглэл үйлдэнэ” гэж заасан.

48. Хэрэв хоригдох этгээд нь гадаад улсын харьяат буюу харьяалалгүй хүн бол дээрх журмын 2.13-т заасныдагуу баривчлах, цагдан хорих байрны дотоод журам болон бусад шаардагдах баримт бичгийг тухайн этгээдийн харьяалах хэл дээр эсхүл англи хэл дээр хөрвүүлж, тоо бүртгэлийн ажилтан танилцуулахаас гадна тухайн орны дипломат төлөөлөгчийн газар буюу консулын газарт нь нэн даруй мэдэгдэх үүрэг хүлээнэ” гэж тус тус заасан байна.

*3-(a)-5 хараат бус хөндлөнгийн эмчид үнэ төлбөргүй үзүүлэн эрүүл мэндийн үзлэгт хамрагдах, энэ тухай хүсэлт гаргах; цагдан хорьсон талаар бүртгэлд тэмдэглэн үлдээх зэрэг орно;*

49. Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/142, А/47 дугаар “Журам батлах тухай” тушаалын 2.3-т “Хорих байрны эмнэлгийн мэргэжилтэн нь хоригдсон этгээдийн эмнэлгийн тусламж авах хүсэлтийн дагуу цаг алдалгүй, эрүүл мэндийн үзлэг хийж, шаардлагатай оношилгоо, эмчилгээнд хамруулна” гэж заасан нь хараат бус хөндлөнгийн эмчид үнэ төлбөргүй үзүүлэх, эрүүл мэндийн үзлэгт хамрагдах хоригдсон хүмүүсийн эрх зүйн баталгаа хангагдсан.

50. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А/185 дугаар тушаалаар батлагдсан “Саатуулах байрны дэглэм, журам”-ын 3.11-д “саатуулагдсан хүнд шаардлагатай тохиолдолд эмнэлгийн яаралтай тусламж болон эмнэлгийн үйлчилгээг цаг хугацаа харгалзахгүй үзүүлэх ба авагдсан эмнэлгийн тусламж, үйлчилгээ, хийгдсэн эмчилгээ, үйлчилгээ үзүүлсэн эмнэлгийн ажилтны талаарх мэдээллийг нарийвчлан авч тэмдэглэл, бүртгэл хөтөлж, тухайн хүний хувийн хэрэгт хавсаргана” гэж заасны дагуу эмнэлгийн үйлчилгээг үзүүлж байна.

51. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/214, А/462 дугаар “Журам батлах тухай” тушаалын 2.2-т “Яаралтай тусламж шаардлагатай бол хорих ангийн эмч нь хоригдлыг хамгийн ойрын эмнэлэгт үзүүлж, эмчлүүлж болно”, 2.3-д “Хүнд өвчний шинж тэмдэг илэрсэн, өвчний онош тодорхойгүй, нэмэлт оношилгоо, шинжилгээ хийлгэх шаардлагатай, онош тодорхой боловч эмчилгээний үр дүн хангалтгүй байгаа тохиолдолд Нэгдсэн эмнэлгийн эмнэлэг, хяналтын комиссын шийдвэрийг үндэслэн хоригдлыг төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, аймгийн нэгдсэн эмнэлэгт шилжүүлнэ” гэж тус тус заасан.

*3-(b) Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа эрх чөлөөгөө хасуулсан хүмүүс цагдан хорих хугацааг гэр бүлийн гишүүд болон түүний сонгосон бусад хүмүүст мэдэгдэх, насанд хүрээгүй хүний хувьд ар гэрийнхэнд болон насанд хүрээгүй хүмүүсийн асуудал хариуцсан зөвлөлд мэдэгдэх, баривчилснаас хойш зургаан цаг хүртэл хугацаагаар цагдан хорьж байгаа эсэх;<sup>21</sup>*

52. Зөрчлийн тухай хуулийн 3.2<sup>22</sup> дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Зөрчил үйлдсэн, зөрчил үйлдэх үедээ арван зургаан насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хүнд энэ хуульд заасан шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ” гэж заасан бөгөөд насанд хүрээгүй хүнийг саатуулах асуудал Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.2<sup>23</sup> дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар зохицуулагддаг.

<sup>21</sup> CAT/C/MNG/CO/2/Add.1, 4 болон 14 дэх хэсэг.

<sup>22</sup> Шийтгэл хүлээх хүн, хуулийн этгээд

<sup>23</sup> Хүнийг саатуулах

53. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.2<sup>24</sup> дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Хүнийг саатуулсан бол хаана байгаа талаар түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, төрөл, садангийн хүн, өмгөөлөгчийн хэн нэгэнд, эсхүл түүний мэдэгдэхийг хүссэн хүнд 8 цагийн дотор мэдэгдэнэ” гэж заасан.

54. Хүнийг саатуулах ажиллагаатай холбоотой харилцааг Улсын Ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2017 оны А/70, А-174 дугаар тушаалаар батлагдсан журмаар зохицуулсан.

55. Түр саатуулах байрны дэглэм, журмыг<sup>25</sup> Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/85 дугаар тушаалаар баталсан. Тус журмын 2.4-т “Түр саатуулах байранд эрэгтэй хүнийг эмэгтэй хүнээс, өсвөр насны хүнийг насанд хүрсэн хүнээс тусад нь байрлуулна. Бэлгийн чиг баримжаа өөр буюу ЛГБТ хүнийг түүний хүсэлтийг харгалзан тусад нь байрлуулах арга хэмжээ авч байна.

56. Дээрх журамд нэмэлт, өөрчлөлт оруулахаар журмын төсөлд олон нийтээс нээлттэй санал авч байна. Төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамны вэбсайт дээр байрлуулсан бөгөөд [juram@mojha.gov.mn](mailto:juram@mojha.gov.mn) хаягаар санал авч байна.<sup>26</sup>

57. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь 2016 онд батлагдсан Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасны дагуу гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий орон нутгийн нэгж юм. (Тайлангийн 37, 38 дахь хэсгийг үзнэ үү.)

58. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны хамтарсан А51/А69 дугаар тушаалаар баталсан. Тус журмын 5.1.3-т заасны дагуу Хороо нь хууль зөрчсөн хүүхдийн мэдээллийг цагдаагийн байгууллага болон бусад этгээдээс хүлээн авсны дараа нэн даруй хууль зөрчсөн хүүхэд болон түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчтэй уулзах уулзалтыг зохион байгуулна. Өмгөөлөгчөө сонгох боломжгүй, өмгөөлөгч авах төлбөрийн чадваргүй нь тогтоогдвол Монголын хуульчдын холбоо болон бусад холбогдох байгууллагад хандан өмгөөлөгчөө сонгох эсвэл томилуулах, Хууль зүйн туслалцааны төвд хандан улсын өмгөөлөгч авах боломжоор хангана.

---

<sup>24</sup> Хүнийг саатуулах

<sup>25</sup> Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/85 дугаар тушаалаар баталсан. Тус журамд 2019 оны А/45 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт орсон.

<sup>26</sup> <https://mojha.gov.mn/newmojha/?topic=%D1%81%D0%B0%D0%B0%D1%82%D1%83%D0%BB%D0%B0%D1%85-%D0%B1%D0%B0%D0%B9%D1%80%D0%BD%D1%8B-%D0%B4%D1%8D%D0%B3%D0%B-%D1%8D%D0%BC-%D0%B6%D1%83%D1%80%D0%B0%D0%BC-%D1%8B%D0%BD-%D1%82%D3%A9>

*3–(с) Цагдан хоригдож байгаа хүнийг буруутгагдаж байгаа хэрэгтээ гэм буруутай гэдгээ хүлээсэн нөхцөлд гэр бүлийн гишүүдтэй нь уулзуулна гэж эрхийг нь мөрдөн байцаагч болон прокурорууд хязгаарлаж буй эсэхийг нягтлах талаар авсан тусгай арга хэмжээнүүд;*

59. Цагдан хоригдож байгаа хүнийг буруутгагдаж байгаа хэрэгтээ гэм буруутай гэдгээ хүлээсэн нөхцөлд гэр бүлийн гишүүдтэй нь уулзуулна гэж эрхийг хязгаарлаж буй байдал байхгүй. Гэм бурууг өөрөөр нь хүлээлгэх арга барилаас зайлсхийх, нотлох баримтад тулгуурлан гэм бурууг бусад аргаар нотлох арга барилд мөрдөн байцаагч болон прокуроруудыг суралцуулах, тэдгээрийн энэ талаарх ойлголтыг нэмэгдүүлэх сургалтууд хийгдэж байна.

*3–(d) Хоригдож байгаа хүний гэр бүлийн гишүүд эргэлт хийх боломжит орон зайд байдаг хорих байранд хорьж байгаа эсэхийг нягтлах талаар авсан арга хэмжээнүүд.*

60. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын 2017 оны 07 дугаар сарын 04–ний өдрийн А/186, А74 дүгээр хамтарсан тушаалаар “Шинээр хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ял эдлүүлэх хорих анги болон хорих ангийн зэрэглэлийг тогтоох чиг үүрэг бүхий зөвлөл”, “Зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийг тус тус батлан, хэрэгжүүлж байна.

61. Шинээр хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ял эдлүүлэх хорих анги болон хорих ангийн зэрэглэлийг тогтоох чиг үүрэг зөвлөл нь хоригдлыг түүний ар гэрийнх нь оршин суугаа газарт ойр байрлах хорих ангид хуваарилах зарчмыг баримтлан шийдвэр гаргадаг. Журмын дагуу хуваарилалт хийгдэж байгаа эсэхэд прокурорын байгууллага хяналт тавьж ажилладаг. Тайлангийн хугацаанд хоригдлууд, түүний ар гэрээс ямар нэг гомдол прокурорын байгууллагад ирээгүй болно.

62. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 207 дугаар зүйлийн 207.5.6–д хоригдол тухайн ангид ял эдлэхээр ирсэн талаар түүний ар гэрт нь мэдэгдэж, хорих ангийн байршил, хориглох эд зүйлсийг танилцуулах талаар заасан.

63. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 19.2 дугаар зүйлд “Хоригдсон этгээдийг хорих шийдвэр гаргасан албан тушаалтан буюу түүний удирдах дээд албан тушаалтны бичгээр олгосон зөвшөөрлөөр төрөл садан болон бусад хүмүүстэй уулзуулж болно” гэж заасны дагуу уулзалтыг зохион байгуулдаг. Өмгөөлөгч хорих байранд саадгүй нэвтэрч хоригдсон этгээдтэй уулзах нөхцөл боломжоор бүрэн хангагдсан.

64. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 198 дугаар зүйлийн 198.3 дахь хэсэгт заасны дагуу “Нээлттэй хорих ангийн ангийн зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол 30 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж болох бөгөөд түр хугацааны уулзалт хийх, захидал илгээх, илгээмж авах, утсаар ярих тоог хязгаарлахгүй”, 199 дүгээр зүйлийн 199.4 дэх хэсэгт “Хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол нь 60 хоногт нэг удаа түр, 90 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 30 хоногт нэг удаа илгээмж авч, нэг удаа утсаар ярьж болно”, мөн зүйлийн 199.5 дахь хэсэгт “Хаалттай

хорих ангийн тусгай зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол 90 хоногт нэг удаа түр, 120 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 60 хоногт нэг удаа илгээмж авч, нэг удаа утсаар ярьж болно” гэж заасны дагуу хоригдол, хоригдогсдын эрхийг ханган ажиллаж байна.

65. Хорих ангийн дотоод журмыг Хууль зүй, дотоод хэргийн сайд 2017 оны А/183 дугаар тушаалаар баталсан. Тус журмаар түр, удаан хугацааны уулзалт хийх асуудлыг тусгаж өгсөн. Түүнчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2018 оны 09 дүгээр сарын 24–ний өдрийн А/165 дугаар тушаалаар “Цахим уулзалт зохион байгуулах журам”–ыг баталж хорих анги, байгууллагуудад цахим уулзалтыг зохион байгуулж байна. 2020 оны 09 дүгээр сарын байдлаар давхардсан тоогоор 5168 удаа хоригдлын түр хугацааны уулзалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан. Нийт уулзалттай харьцуулахад цахим уулзалтын эзлэх хувь байгаа нь гэр бүлийн гишүүдтэйгээ орон зай харгалзахгүй уулзах нөхцөл боломжоор хангагдаж байгааг харуулж байна.

66. Гадаад улсын харьяат буюу харьяалалгүй хүн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан тохиолдолд “Хорих байрны дотоод журам”–ын 2.13–т зааснаар тухайн этгээдийн харьяалах улсын хэл дээр эсхүл англи хэл дээр холбогдох хууль, журмыг танилцуулахаас гадна тухайн орны дипломат төлөөлөгчийн газар буюу консулын газарт албан бичгээр мэдэгддэг. Хоригдсон этгээд нь хорих байрны захиргаагаар уламжлуулан өөрийн улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газрын ажилтантай уулзахад уулзалтын тоо, хугацаанд ямар нэг хязгаарлалт тогтоодоггүй болно.

4. Хорооноос өмнө өгсөн ажиглалт дүгнэлт (13 болон 14 дэх параграф)<sup>27</sup>–н дагуу дараах мэдээллийг бэлтгэн ирүүлнэ үү.

*4–(а) Шүүх хурал болохоос өмнө цагдан хорих (pretrial detention) хугацааг багасгах талаар хуульд аливаа өөрчлөлт орсон эсэх;*

67. Сэжигтэн, яллагдагчийг баривчлан саатуулсан үеэс хугацааг тоолдог байх зарчим 2017 онд батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар улам боловсронгуй болж батлагдсан. Тус сэжигтэн, яллагдагчийг цагдан хорьж, мөрдөх хугацааг багасган

---

<sup>27</sup> 13. Хороо нь цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээнээс гадна өргөн хүрээний тухайлбал, хорио цээрийн арга хэмжээ авах, хуулиар тогтоосон хугацаанаас илүү хугацаагаар хорих зэрэг явдал илтгэлд байгаад анхаарлаа хандуулж байна. Түүнчлэн цагдан хоригдож байгаа хүмүүсийн 12–оос дээш хувь нь 12 сараас илүү хугацаагаар хоригдож байсан бол 3–аас дээш хувь нь 30 сараас илүү хугацаагаар саатуулагдсан байдаг. Хороо нь цагдан хоригдсон тус хугацаанууд шүүхээр шийдэгдсэн хорих нийт хугацаанд тооцогдохгүй байгаад зовниж байна. (2 болон 11 дүгээр зүйл)

14. Орлоцогч улс нь:

Хууль тогтоомжид цагдан хорих хугацааг багасгах чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулах, ингэхдээ зайлшгүй тохиолдолд хязгаарлагдмал хугацаагаар хэрэглэх, хууль тогтоомжийн үндсэн суурь болон байцаан шийтгэх ажиллагааны үндсэн баталгаа болгохын тулд шүүхийн хяналтанд байхаар зохицуулах;

Хэн ч хуулинд зааснаас илүү хугацаагаар цагдан хорих газар хоригдохгүй ба энэхүү хоригдсон хугацааг тухайн гэмт үйлдэлд нь олгосон ял болох шоронд өнгөрүүлэх хугацаанд тооцон оруулах;

Цагдан хорих ажиллагааг НҮБ–ын урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах стандарт журмын дагуу урьдчилан сэргийлэх гэхийн оронд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах гэж солих (Токиогийн дүрэм);

Шударга бусаар саатуулагдсан хохирогчдыг цагаатгах болон нөхөн олговрыг олгодог байх.

хуульчилсан. Тухайлбал өмнөх хуулиар яллагдагчийг цагдан хорих үндсэн хугацаа 2 сар байсан бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлд зааснаар энэ хугацаа 1 сар байхаар зохицуулагдсан.

68. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.9 дүгээр зүйлийн 1–д зааснаар цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг зөвхөн шүүхийн шийдвэрээр авдаг.

69. Хэргийн ээдрээ төвөгтэй байдлыг харгалзан шүүх цагдан хорих хугацааг зайлшгүй гэж үзсэн тохиолдолд сунгана. Яллагдагчийг цагдан хорих нийт хугацаа Эрүүгийн хуульд хорих ялын дээд хэмжээг 5 жил хүртэл хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэрэгт 12 сар, Эрүүгийн хуульд хорих ялын дээд хэмжээг 5 жилээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэрэгт 18 сараас хэтэрч болохгүй.

70. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.13 дугаар зүйлийн 1 болон 7 дахь хэсэгт цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, хүчингүй болох, сунгаж болохоор зохицуулсан. Тайлангийн хугацаанд шүүх хурал болохоос өмнө цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөр таслан сэргийлэх арга хэмжээгээр сольсон тохиолдол 528 удаа гарсан байна.

*4–(b) Цагдан хорих хугацааг тоолж эхлэхдээ тухайн хүний эрх чөлөөг хасаж эхэлсэн цаг мөчөөс тоолдог эсэх, цагдан хоригдсон хугацааг ял шийтгэл эдлэх хугацаанд оруулж тооцох талаар хууль тогтоомжид аливаа нэмэлт, өөрчлөлт оруулсан эсэх;*

71. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах шийдвэрийг шүүх гаргах бөгөөд Яллагдагчийг цагдан хорих тухай шүүгчийн захирамж гарснаар цагдан хорих хугацааг тоолж эхэлнэ.

72. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.9 дүгээр зүйлд баривчлах хугацааг тоолох талаар зохицуулсан. Баривчилж байгаа тохиолдолд сэжигтэнд баривчлах тухай шүүхийн шийдвэрийг танилцуулсан үеэс баривчилсан хугацааг тоолохоор 31.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан. Шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан тохиолдолд ямар гэмт хэрэгт сэжиглэж байгаа, хууль зүйн туслалцаа авах эрхтэй болох, сэжигтний хийсэн үйлдэл, хэлсэн үг өөрийнх нь эсрэг шүүхэд нотлох баримт болохыг анхааруулж, хууль ёсны шаардлагыг биелүүлэхгүй бол холбогдох хуульд заасны дагуу албадлага хэрэглэхийг сануулсан үеэс буюу эдгээр эрхийг танилцуулсан үеэс баривчилсан хугацааг тоолохоор хуульчилсан байна.

73. Эрүүгийн хуулийн 6.10 дугаар зүйлд зааснаар шүүх баривчлагдсан, цагдан хоригдсон хугацааг ялтны эдлэх ялд оруулан тооцдог ба баривчлагдсан, цагдан хоригдсон нэг хоногийг торгох ялын арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, нийтэд тустай ажил хийлгэх ялын найман цагаар, зорчих эрхийг хязгаарлах ялын нэг хоногоор, хорих ялын нэг хоногоор тооцож эдлэх ялаас хасаж тооцохоор хуульчилсан болно.

74. Нэг хэрэгт дахин, эсхүл тусгаарласан, нэгтгэсэн хэрэгт шинээр цагдан хоригдсон бол өмнө нь цагдан хоригдсон хугацааг нийт цагдан хоригдсон хугацаанд оруулж тооцно.

75. Баривчлагдсан хугацааг цагдан хорих хугацаанд оруулж тооцно. Баривчлагдсан 24 цаг хүртэл хугацааг цагдан хоригдсон 1 хоногоор тооцохоор Эрүүгийн хэрэг хянан

шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт хуульчилсан.

76. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан дээрх зохицуулалтуудын хэрэгжилтэд прокурорын байгууллага хяналт тавьдаг. Эрүүгийн хуулийн 6.10 дахь хэсэгт зааснаар шүүхээс баривчлагдсан, цагдан хоригдсон хугацааг ялтны эдлэх ялд оруулан тооцож, шийтгэх тогтоолдоо дурддаг.

*4–(d) Цагдаагийн хэсэг дээр цагдан хоригдож байгаа хүнийг материаллаг нөхцөл байдлаар зохих ёсоор хангадаг эсэх; хоол, ундны ус, эрүүл ахуйн болон ариун цэврийн байгууламжаар хангагдсан эсэх;*

77. Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–г “Цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэг, зөрчил үйлдсэнд сэрдэгдэж байгаа хүний нэр, хаягийг тодруулах, гэмт хэрэг, зөрчилд холбогдуулан шалгах, албадан саатуулах үндэслэл байгаа эсэхийг тогтоох зорилгоор хүнийг 6 цаг хүртэл хугацаагаар түр саатуулж болно” гэж заасан.

78. Хуульд заасан үндэслэлийн дагуу саатуулах эрх хязгаарлах арга хэмжээ авагдсан хүнийг хүлээн авч, саатуулах шийдвэрийг хэрэгжүүлэх нэгжийг саатуулах байр гэх бөгөөд “Саатуулах байрны дэглэм журам”–ыг Улсын Ерөнхий Прокурортой зөвшилцөн дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, мөрдүүлдэг.

79. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дээрх журмын 2.1–г “Саатуулах байр нь халуун, хүйтэн ус, бохирын систем, байгалийн гэрэлтүүлэг, агааржуулалтын систем зэрэг ажиллагсад, үйлчлүүлэгчдийн эрүүл мэнд, аюулгүй байдлын шаардлагыг хангахуйц орчин, нөхцөлийг бүрдүүлсэн байна” гэж заасны дагуу саатуулах байрыг эмчийн үзлэг хийх, гал тогооны, бие засах, саатуулагдсан хүмүүсийн хувцас, биедээ авч яваа бичиг баримт, бусад эд зүйлийг хадгалах өрөөтэй байхаар тохижуулсан.

80. Саатуулах байрууд нь хүйтний улиралд 18 градусаас доошгүй хэмийн дулаан, чийглэг нь 40–60 хувьтай байх ба гадна талаасаа агаар болон гэрэл орох салхивчтай, шөнийн цагт ашиглах унтраалга бүхий гэрэлтүүлэгтэй болгосон.

81. Саатуулах байрны өрөө нь саатуулагдсан нэг хүнд 2м<sup>2</sup>-аас доошгүй талбай ногдох нөхцлийг бүрдүүлээд байна.

82. Хүний эрхийн үндэсний комисс болон прокурорын байгууллагаас 24 цагийн хугацаанд буюу аль ч үед цагдан хорих байрны ахуй нөхцөл, үйл ажиллагаа олон улсын гэрээ, хууль тогтоомж, заавар журамд заасан шаардлагын хэмжээнд байгаа эсэхийг улсын хэмжээнд шалгах ажлуудыг тогтмол хийж байна.

83. Зөрчлийг арилгах талаар прокуророос цагдаагийн байгууллагад шаардлага хүргүүлдэг. Шаардлагын дагуу зөрчлийг засуулах арга хэмжээ авдаг.

*4-(d) Цагдаагийн зүгээс эхний удаад баривчлан саатуулахгүй байхыг чухалчилдаг эсэх эсхүл хэн нэгнийг хуульд заасан хугацаанаас илүү хугацаагаар саатуулж, баривчлахгүй байхыг чухалдаг эсэхийг нягтлах талаар авсан тодорхой арга хэмжээ;<sup>28</sup>*

84. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.5 дугаар зүйлд сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах асуудлыг хуульчилж өгсөн. Гэмт хэрэг үйлдэж байх үед, эсхүл үйлдсэн дор нь барьсан, эсхүл хуульд заасан хойшлуулшгүй тохиолдолд, эсхүл гэмт хэрэг үйлдсэн гэж гэрч, хохирогч шууд заасан, эсхүл тухайн хүний хувцас, бие, орон байр, эд зүйл, тээврийн хэрэгсэлд гэмт хэргийн ул мөр илэрсэн тохиолдолд сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчилна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.5 дугаар зүйлийн 3-т зааснаар мөрдөгч сэжигтнийг баривчилсан бол асуудлыг 24 цагийн дотор шүүх шийдвэрлэнэ.

85. Шүүхээс баривчлагдсан сэжигтнийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.12 дугаар зүйлд заасан үндэслэлүүдээр суллах шийдвэр гаргана. Тухайлбал: гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай баримт байхгүй, баривчилснаас хойш 48 цаг дуусч, сэжиглэгдэж байгаа хүнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах прокурорын шийдвэр, цагдан хорих шүүхийн шийдвэр ирээгүй, эсхүл шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах үндэслэлүүдийг зөрчиж баривчлах зэрэг болно.

86. Шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан боловч баривчилснаас хойш 48 цаг дууссан бөгөөд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах прокурорын шийдвэр, цагдан хорих шүүхийн шийдвэр ирээгүй байхад сэжигтнийг суллахгүй байлгах, илүү хугацаагаар саатуулахгүйн тулд хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс прокурорууд 24 цагаар ажилладаг.

*4-(e) Шүүхийн өмнөх цагдан хорих (pretrial detention) асуудал зохицуулалттай байдаг эсэх, суурь эрхийг баталгаажуулах болон процесс ажиллагааны аюулгүй байдлыг хангахын тулд шүүхийн хяналт дор цагдан хорих ажиллагааг явуулдаг эсэх;*

87. Мөрдөн байцаалтын шатанд шүүхээс зөвшөөрөл авч, шүүхэд хэргийг хянан шийдвэрлэх шатанд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг гагцхүү шүүх авч байна.

88. Суурь эрхийг баталгаажуулах болон процесс ажиллагааны аюулгүй байдлыг хангахын тулд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт мөрдөгч сэжигтнийг баривчилсан даруй прокурорт мэдэгдэж, прокурор шийдвэрийг шүүхэд даруй хүргүүлэхээр зохицуулсан. (Тайлангийн 77 дахь хэсгийг үзнэүү.)

*4-(f) Цагдан хоригдож байгаа хүнтэй уулзалт товлох нь прокурорын эрх хэмжээний асуудал эсэх;*

89. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 17 дугаар зүйлд хоригдсон этгээдийн эрхийг тусгайлан баталгаажуулан заасан. Хоригдож буй этгээд эргэлт авах, уулзалт хийх эрхийг тус хуулийн 17 дугаар зүйлийн

<sup>28</sup> CAT/OP/MNG/1, 51 (a) хэсэг.



17.1.15–д хуульчилсан болно. Мөрдөн шалгах ажиллагааны нууцлалыг хангах зорилгоор уг эрхийг хэрхэн эдлүүлэх асуудал тусгайлсан журмаар зохицуулагддаг. Мөрдөн шалгах ажиллагааны явцад мөрдөгч, прокурорын хяналтын шатанд прокурор, хэргийг шүүхийн журмаар хянан шийдвэрлэх шатанд шүүгч тус тус эргэлт, уулзалтын зөвшөөрлийг олгодог.

90. Цагдан хоригдож буй хүнтэй уулзах зөвшөөрөл олгогдсон хүнийг уулзалт хийлгэх ажиллагааг баривчлах, цагдан хорих газрын хяналт дор явуулдаг. Хоригдож буй хүний өмгөөлөгч тухайн хүнтэй уулзахад ямар нэг зөвшөөрөл шаардахгүй. Монгол Улсын Үндсэн хуульд заасан эрх хэмжээний хүрээнд прокурор баривчлах, цагдан хорих ажиллагаанд бүхэлд нь хяналт тавьж, хоригдож буй хүний эрхийг хангуулах үүрэгтэй.

*4–(g) Шүүх хурал болохоос өмнөх хяналтын хугацаанд цагдан хорио (pretrial detention)–г хорихоос өөр арга хэмжээгээр сольж байгаа эсэх, ямар харьцааг баримталж сольж байгаа талаар;*

91. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хүнийг аль болох цагдан хорихгүй байхыг чухалчилж, хорих үндэслэлүүдийг тодорхой болгосон төдийгүй цагдан хорих үндэслэлгүй тохиолдолд бусад таслан сэргийлэх арга хэмжээг авахаар зохицуулсан.

92. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр бүлэгт таслан сэргийлэх арга хэмжээнүүдийн зорилго, төрлийг тодорхой тусгасан. Тодруулбал: 1/ хувийн баталгаа гаргах; 2/тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх; 3/хязгаарлалт тогтоох; 4/барьцаа авах; 5/цагдан хорих; 6/цэргийн ангийн удирдлагад хянан харгалзуулах гэсэн таслан сэргийлэх арга хэмжээний төрлүүдийг хуульчилсан.

93. Яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, хүчингүй болгуулах хүсэлт прокурорт гаргаж болно. Прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.2, 1.3, 1.5–д заасан таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох, хугацааг сунгах санал, хүсэлтийг шүүхэд гаргаж болно гэж тус тус заасны дагуу таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх эсэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ.

*4–(h) Тодорхойгүй хугацаагаар цагдан хоригдсон (pretrial detention) хохирогчид нөхөн төлбөр авдаг эсэх, тэдэнд хандсан нөхөн олговор байдаг эсэх;*

94. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх, прокурор, мөрдөгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, гомдол гаргах эрхийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.7 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 8.2 дугаар зүйлийн 1.12 дахь хэсэг, 45.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тус тус хуульчилж өгсөн.

95. Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Дөчин тавдугаар бүлэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх, прокурор, мөрдөгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах зохицуулалтыг бүрэн тусгасан. Тус хуулийн 45.2 дугаар зүйлийн 1–д “Хүнийг хууль бусаар ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон ... эрүүдэн шүүсний улмаас учирсан хохирлыг мөрдөгч, прокурор, шүүгчийн гэм бурууг үл харгалзан төр хариуцан арилгана” гэж заасан.

96. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн<sup>29</sup> 5 дугаар зүйлийн 5.3.4 дэх заалт, 10 дугаар зүйлд гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн талаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн нийт 21 зүйлд заасан гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох ажлыг зохион байгуулж байна. Үүнд: 10.1 дүгээр зүйл /Хүнийг алах/; 11.1 дүгээр зүйл /Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах/; 11.4 дүгээр зүйл /Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах/; 12.1 дүгээр зүйл /Хүчиндэх/; 12.3 дугаар зүйл /Бэлгийн мөлжлөг/; 13.1 дүгээр зүйл /Хүн худалдаалах/; 13.2 дугаар зүйл /Хүн хулгайлах/; 13.3 дугаар зүйл /Хүн барьцаалах/, 13.4 дүгээр зүйл /Хүнийг хүчээр алга болгох/; 15.3 дугаар зүйл /Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах/; 15.5 дугаар зүйл /Хууль бусаар үр хөндөх/; 16.1 дүгээр зүйл /Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах/; 16.3 дугаар зүйл /Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх/; 16.6 дугаар зүйл /Хүүхэд худалдах/; 16.7 дугаар зүйл /Хүүхэдтэй хэрцгий харьцах/; 16.11 дүгээр зүйл /Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх/; 17.2 дугаар зүйл /Дээрэмдэх/; 19.3 дугаар зүйл /Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах/; 21.12 дугаар зүйл /Эрүү шүүлт тулгах/; 29.1 дүгээр зүйл /Түрэмгий дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх/; 29.8 дугаар зүйл /Террорист үйлдэл хийх/ зэрэг болно. Гэмт хэргийн хохирогчид олгох нөхөн төлбөрийн хэмжээ нь хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх тухай шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тодорхойлогдоно.

Сангийн зарцуулалтыг тайланд хамарч буй хугацаагаар буюу 2016 оноос хойш дор хүснэгтэд үзүүлэв. Нийт 200 төлбөр авагч /хохирогч/-д 1.1 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг төрөөс олгох шийдвэр гүйцэтгэх ажиллагаа зохион байгуулагдсан байна.

№	Нөхөн төлбөр олгосон огноо	Төлбөр авагч /хохирогч/-ын тоо	Олгосон нөхөн төлбөрийн хэмжээ /мян.төг/
1	2016 он	60	234.738.816
2	2017 он	39	83.075.873
3	2018 он	31	160.614.925
4	2019 он	37	223.905.082
5	2020 он	33	411.780.752
Нийт дүн		200	1.114.115.448

<sup>29</sup> 2019 онд шинэчилсэн найруулга батлагдсан.

97. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.6 дугаар зүйлийн 2–т “Хүнийг ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авсан, эмнэлгийн байгууллагад байлгасан тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсний дараа уг ажиллагаа хууль бус болох нь нотлогдвол холбогдох хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага, прокурор, шүүх олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хийсэн мэдээлэлдээ залруулга хийж, шийдвэр гарснаас хойш 7 хоногийн дотор олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ” гэж заасан.

98. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсэгт заасны дагуу хорих байрны дарга нь хоригдсон этгээдийг хуульд заасан хорих хугацаа дуусах болсон тухай 24 цагаас доошгүй хугацааны өмнө хорих шийдвэр гаргасан албан тушаалтанд болон харьяалах прокурорт бичгээр мэдэгддэг.

99. Тайлангийн хугацаанд тодорхойгүй хугацаагаар цагдан хоригдсон тохиолдол гараагүй болно.

*4–(i) Оролцогч Улсад яг одоогоор цагдан хоригдож байгаа хүний тоо тэр дундаа шүүхийн шийдвэргүйгээр хоригдогсод, мөн захиргааны процесс ажиллагааны дагуу хоригдсон хүмүүсийн тоо;*

100. 2020 оны эхний 9 сарын байдлаар цагдан хорих төвд 585, орон нутаг дахь цагдан хорих байранд 290 этгээдийг хойшлуулшгүй ажиллагааны явцад баривчлан түр хорьсон байна. Тус хугацаанд шүүхийн шийдвэргүйгээр буюу мөрдөн байцаагч, прокурорын тогтоолоор хойшлуулшгүй ажиллагааны явцад баривчилсан 8 тохиолдол гарсан.

### **Эрүүдэн шүүх үйлдэл гаргагчид ял завшуулахгүй байх**

*5. Хорооноос өмнө өгсөн ажиглалт дүгнэлтийн (15, 16 дахь параграф) дагуудараах мэдээллийг гаргаж өгнө үү.*

*5(а)–Төрийн албан хаагчийн тодруулбал цагдаагийн албан хаагчийн үйлдсэн эрүүдэн шүүх, хүнлэг бусаар харьцсан үйлдлийг Мөрдөн шалгах тусгай чиг үүрэг бүхий бие даасан нэгж (Улсын Ерөнхий Прокурорын газрын дэргэд байсан)–ийг татан буугдсанаас хойш эрүүдэн шүүсэн, хүнлэг бусаар хандсан аливаа үйлдлийг ял шийтгэлгүй өнгөрөөхгүй байх, түүнтэй тэмцэхэд гаргасан аливаа тодорхой ахиц байгаа эсэх; тайлангийн хугацаанд эрүүдэн шүүх, хүнлэг бусаар харьцсан үйлдэлд ял шийтгэл оногдуулахгүй байхтай тэмцэх, тэр дундаа эрүүгийн хэрэг нээхээс татгалзах, мэдээлэл дутмаг байсны улмаас эцсийн үр дүнд нөлөөлөх зэрэг ял шийтгэлгүй өнгөрөөхгүй байх чиглэлээр Авилгатай тэмцэх газар болон ЦЕГ–ын Мөрдөн байцаах албанаас гаргаж байгаа аливаа хүчин чармайлт, гаргасан дэвшил;*

101. Тайлангийн хугацаанд эрүү шүүлтээс ангид байх эрх нь зөрчигдсөн гэж үзэж буй иргэдийн гомдлыг барагдуулах үүднээс Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 12–ны өдрийн А/104 дүгээр тушаалаар Ажлын хэсэг байгуулан

ажилласан. 2018, 2019 онуудад холбогдох төрийн албан хаагчийн тодруулбал цагдаагийн албан хаагчийн үйлдсэн гэх эрүүдэн шүүх, хүнлэг бусаар харьцсан үйлдэлд гомдол гаргасан нэр бүхий 44 иргэний мэдээллийг хүн тус бүрээр хэлэлцэж дүгнэлт гарган, Улсын Ерөнхий прокурорын газарт шилжүүлсэн. Улсын Ерөнхий прокурорын газраас 44 иргэний гомдол, мэдээлэлд дурдагдсан асуудлыг хүлээн авч, шалгасан эсэхийг тодруулахад 25 гомдлыг харьяаллын дагуу мөрдөх байгууллагуудад 2019 оны 7 дугаар сард шилжүүлж, 19 гомдлыг гэмт хэргийн шинжгүй гэх үндэслэлээр прокурорын тогтоолоор хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн байна.

102. Улсын Ерөнхий прокурорын газарт эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 2016 онд нийт 54 бүртгэгдсэнээс 10 гомдол, мэдээлэл буюу 18.5 хувьд нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, 33 гомдол, мэдээлэл буюу 61 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, 11 буюу 20.4 хувьд нь прокурор гомдлыг хүлээн авахаас татгалзсан, 2017 онд нийт 67 гомдол, мэдээлэл хүлээн авснаас 6 гомдолд эрүүгийн хэрэг үүсгэж, мөрдөн шалгах ажиллагаа явуулсан, 61 гомдолд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах буюу хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан, 2018 онд нийт 69 гомдол, мэдээлэл бүртгэгдсэнээс 22 гомдолд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 46 гомдлын мөрөөр хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, мөрдөн шалгах ажиллагаа явуулсан бол хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн мөрдөгчийн 1 тогтоолыг хүчингүй болгосон, 2019 онд нийт 87 гомдол бүртгэгдсэнээс 1 гомдолд өмнө гаргасан шийдвэр, үйл ажиллагааг хүчингүй болгон, 34 гомдлыг хүлээн авахаас татгалзаж, 13 гомдлыг хүлээн авсан, 39 гомдлыг харьяаллаар шилжүүлсэн.

*5(b)–Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх бие даасан хараат бусаар мөрдөн шалгах эрхтэй нэгжийг дахин бий болгох талаар авсан аливаа арга хэмжээ;<sup>30</sup>*

103. Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх мөрдөн байцаах албыг сэргээх асуудлаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж УИХ–д танилцуулсан боловч хууль тогтоогчоос дэмжээгүй болно. Засгийн газрын 2020–2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Монгол Улс дахь мөрдөх байгууллагуудын үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилт тусгагдсан болно.

104. Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх мөрдөн байцаах алба нь 2002 оноос 2014 оны 01 дүгээр сарын 24–ний өдрийг хүртэл хугацаанд ажиллахдаа 6109 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргаж прокурорт 3344, харьяаллын дагуу шилжүүлсэн 1256, эрүүгийн хэрэг үүсгэж мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан 2972, үүнээс 1370 хэргийг яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлж шийдвэрлүүлж байсан байна.

105. Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 оны 7 дугаар сарын 1–ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэнтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхий прокурорын 2017 оны 6 дугаар сарын 30–ны өдрийн А/67 дугаар тушаалаар “Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгах, түүнд

<sup>30</sup> CAT/OP/MNG/1, 29 хэсэг.

прокурор хяналт тавих харьяалал тогтоох тухай” журмыг баталжээ. Тус журмыг 2020 оны 03 дугаар сарын 24–ний өдрийн А/33 дугаар тушаалаар шинэчлэн баталсан.

106. Дээрх журамд зааснаар цагдаагийн байгууллагын алба хаагчдаас үйлдсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг Авлигатай тэмцэх газарт, Авлигатай тэмцэх газрын алба хаагчийн үйлдсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, гэмт хэргийг Тагнуулын ерөнхий газарт, шүүх, прокурор, Авлигатай тэмцэх газрын алба хаагчдын үйлдсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, гэмт хэргийг Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөх хэлтэст, Тагнуулын байгууллагын алба хаагчийн Гүйцэтгэх ажлын тухай хууль зөрчих гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл гэмт хэргийг Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн алба шалгахар тус тус харьяалал тогтоосон байна.

*5(c)–Хорооноос өмнө өгсөн ажиглалт дүгнэлтэд дурдагдсан Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албанд мөрдөн шалгуулахаар ирүүлсэн 3 гомдлыг шалгасны дараа эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэлгүй<sup>31</sup>, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан<sup>32</sup> гэж буцаан шийдвэрлэсэн байдалд гомдол гаргасан эсэх;*

107. Хорооноос өмнө өгсөн ажиглалт дүгнэлтэд дурдагдсан Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албанд мөрдөн шалгуулахаар ирүүлсэн 3 гомдлыг тодруулбал эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан 2 гомдол, хэрэгсэхгүй болгосон 1 гомдлыг шийдвэрлэсэн байдалддавж заалдах гомдол гаргаагүй байна.<sup>33</sup>

*5(d)–Мөрдөгчид болон гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээдүүдийн хооронд тэр дундаа Цагдаагийн ерөнхий газраас хийж байгаа мөрдөн шалгах ажиллагаанд институцийн болон шатлан захирах (hierarchical) холбоо байхгүй гэдгийг нягтлах талаар авсан арга хэмжээ, эрүүдэн шүүх гэмт хэрэг үйлдсэн цагдаагийн ажилтнуудыг мөрдөн шалгах харьяалал орон нутгийн цагдаагийн мөрдөн байцаах нэгжүүдэд шилжсэн, мөн үүнтэй холбогдуулан бие даасан хараат бус механизм бий болгох талаар ямар нэг байдлаар анхаарал хандуулах арга хэмжээ авсан эсэх;*

108. (Тайлангийн 96 дахь хэсгийг үзнэүү.) Улсын Ерөнхий прокуророос цагдаагийн байгууллагын алба хаагчдын үйлдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл, эрүүгийн хэргийг хөндлөнгийн байгууллагаар шалгуулах харьяаллыг тогтоож, цагдаагийн байгууллагын алба хаагчдаас үйлдсэн эрүү шүүлт тулгах гэмт хэргийг Авлигатай тэмцэх газар шалгахар харьяалуулсан.

109. Эрүүгийн хуулийн 4.6 дугаар зүйлд тушаал, даалгавар биелүүлэхтэй холбогдсон зохицуулалтыг оруулж өгсөн бөгөөд тус зүйлийн 1 дэх хэсэгт “Цэргийн алба хаагч, хууль сахиулагч дээд шатны албан тушаалтны бичгээр, амаар өгсөн заавал биелүүлэх тушаал, даалгаврыг хууль бус болохыг мэдэх боломжгүй, мэдэлгүйгээр биелүүлж энэ хуулиар

---

<sup>31</sup> CAT/C/MNG/CO/2/Add.1, 32 хэсэг.

<sup>32</sup> CAT/C/MNG/CO/2/Add.1, 33 хэсэг.

<sup>33</sup> Улсын Ерөнхий прокурорын газраас ирүүлсэн мэдээлэл

хамгаалагдсан ашиг сонирхолд хохирол учруулсныг гэмт хэрэгт тооцохгүй. Хууль бус тушаал, даалгавар өгсөн албан тушаалтныг уг гэмт хэргийг үйлдсэн гүйцэтгэгчид тооцно.” гэж заасан. Мөн тус зүйлийн 2 дахь хэсэгт “Энэ хуульд заасан илэрхий гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхгүйг хийлгэхээр өгсөн илт хууль бус тушаал, шийдвэр нь цэргийн алба хаагч, хууль сахиулагч өөрөө бие даан шийдвэрлэх ёстой албаны үүрэг, эрх мэдэлд хамаарахаар байтал уг даалгаврыг зориуд биелүүлсэн бол тухайн цэргийн алба хаагч, хууль сахиулагчийг уг гэмт хэргийг үйлдсэн гүйцэтгэгчид, тушаал, даалгавар өгсөн албан тушаалтныг бусдыг ашиглан гэмт хэрэг үйлдсэн гүйцэтгэгчид тооцох” ба илт хууль бус тушаал, даалгаврыг биелүүлээгүй тохиолдолд тушаал, даалгавар өгсөн хүнийг уг гэмт хэргийг үйлдэхээр завдсанд тооцохоор хуульчилсан.

110. Түүнчлэн Цагдаагийн албаны тухай хуулийн 5.4–т “Цагдаагийн алба хаагч дээд шатны цагдаагийн байгууллага, албан тушаалтны гаргасан хууль бус шийдвэрийг биелүүлэхээс татгалзаж, үндэслэлээ тайлбарлах эрхтэй” гэж заасан. Энэ нь хуульд нийцээгүй буюу эрүү шүүлт тулгахыг тушаах, зөвшөөрөх, эсхүл дэмжсэн тушаал зааварыг биелүүлэхгүй байх баталгаа төдийгүй ийм шийдвэрийг биелүүлээгүйгээс ямар нэг хариуцлага хүлээхгүй байхаар заасан.

*5(е)–Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйлд жагсаасан эрүүгийн хэргийг мөрдөн шалгах харьяалал Авлигатай тэмцэх газарт бий эсэх;*

111. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2.3 дугаар зүйлээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах харьяаллыг тогтоож өгсөн. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу явуулна. Хуульд заасны дагуу тагнуулын байгууллага, цагдаагийн байгууллага, Авлигатай тэмцэх газар нь прокурорын шийдвэрээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг хамтран явуулж болно. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах хэд хэдэн байгууллагын эрх хэмжээнд харьяалагдах гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах харьяаллыг прокурор тогтооно. (Тайлангийн 105 дахь хэсгийг гүнзгүүр) Авлигатай тэмцэх газар нь 2017 оны 07 дугаар сарын 01–ний өдрөөс эхлэн цагдаагийн байгууллагын алба хаагчийн үйлдсэн эрүү шүүлт тулгасан гэх гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа болно. 2017–2019 онд гэмт хэргийн шинжтэй 189 гомдол мэдээлэл, эрүүгийн 105 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байна.

112. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2–т Авлигатай тэмцэх байгууллагаас хийх хэрэг бүртгэлт, явуулах мөрдөн байцаалт бүхий гэмт хэргүүдийг хуульчлан тодорхой зааж өгсөн. Тодруулбал: Эрүүгийн хуулийн 22.1 /Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/, 22.3 /Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах/, 22.4 /Хахууль авах/, 22.5 /Хахууль өгөх/, 22.6 /Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах/, 22.7 /Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх/, 22.8 /Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/, 22.9 /Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/, 22.10 /Үндэслэлгүйгээр хөрөнгөжих/, 22.11 /Дураараа аашлах/, 22.12 /Хуулийн этгээдийн

эрх мэдлийг урвуулан ашиглах/ дугаар зүйлд заасан гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна.

113. Мөн Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан авлигын гэмт хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад илрүүлсэн Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд заасан мөнгө угаах гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна.

114. 2002 оны Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйлд “Эрүү шүүлт тулгах” гэмт хэргийг зүйлчилсэн байсан. 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад тус гэмт хэргийг 21.12 дугаар зүйлд зааж өгсөн. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 21.12 дугаар зүйлд заасан гэмт хэргийг үйлдэх субъект нь “төрийн албан хаагч” ихэнх тохиолдолд “мөрдөн шалгах чиг үүрэгтэй байгууллагын албан хаагч” байх тул энэ хэргийг мөрдөн шалгах харьяаллыг прокурор тогтооно. Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгах, түүнд прокурор хяналт тавих харьяалал тогтоох тухай 2020 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/33 дугаар тушаалын 1.3 дугаар зүйлд цагдаагийн алба хаагчийн албан ажлын байранд үйлдсэн, эрүүдэн шүүсэн гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, гэмт хэрэгт Авлигатай тэмцэх газар мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар зохицуулсан.

*5(g)–Цагдаагийн албаны тухай хуулийн 22.4–т заасныг зөрчсөн цагдаагийн алба хаагч тодруулбал эрүү шүүлт тулгасан, хүнлэг бус, хэрцгий, зүй бусаар харьцсан, шийтгэл хүлээлгэсэн тэр дундаа гэмт хэрэг, зөрчилтэй холбогдуулан тайлбар авах, мэдээлэл олж авах зорилгоор шийтгэл хүлээлгэсэн эсхүл ийм үйлдэл хийхийг оролдсон бол түүний албан тушаалыг бууруулах, цагдаагийн цол зэргийг бууруулах, дээрх хуулийн 84.4–т заасны дагуу цагдаагийн албанд ажиллахыг нэг жилийн хугацаагаар түдгэлзүүлэх, тэдний үйлдсэн гэмт хэрэгт тохирох ял шийтгэл бүхий эрүүгийн хариуцлагыг хувь хүнд хүлээлгэхгүй байгаа эсэх;*

115. Цагдаагийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4–т “Цагдаагийн алба хаагч бусдад эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжлохыг хориглоно” гэж заасан.

116. 2013 онд батлагдсан боловч 2017 онд хүчингүй болсон Цагдаагийн албаны тухай хууль нь нийт 42 зүйлтэй байх тул 2013 оны хуулийг ишлээгүйг нотолж байна. 2017 онд батлагдсан Цагдаагийн албаны тухай хуулийн<sup>34</sup> 84 дүгээр зүйлийн 84.4–т “Цагдаагийн байгууллага, алба хаагч үйл ажиллагаандаа улс төрийн намын бэлгэ тэмдэг агуулсан эд зүйл, техник хэрэгсэл ашиглахыг хориглоно” гэж заасан нь асуулттай холбогдолгүй байна. Цагдаагийн албаны тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1.2 дахь заалт асуулттай холбогдож байна. Цагдаагийн албаны тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1.2–т гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон бол албанаас халах үндэслэл болно гэж шинээр заалт оруулсан. Цагдаагийн албаны тухай хуулийн 22.4–т заасныг зөрчсөн цагдаагийн алба хаагч тодруулбал эрүү шүүлт тулгасан, хүнлэг бус, хэрцгий, зүй бусаар харьцсан, шийтгэл хүлээлгэсэн тэр дундаа гэмт хэрэг, зөрчилтэй холбогдуулан тайлбар авах, мэдээлэл олж авах зорилгоор

---

<sup>34</sup> <https://www.legalinfo.mn/law/details/12469?lawid=12469> – сүүлд нэвтэрсэн 2020 оны 08 дугаар сарын 01–ний өдөр

шийтгэл хүлээлгэсэн эсхүл ийм үйлдэл хийхийг оролдсон болох нь тогтоогдсон тохиолдолд Эрүүгийн хуульд заасан Эрүү шүүлт тулгах гэмт хэргээр зүйлчлэгдэхээр зохицуулалттай байна. (Тайлангийн 20–23 дахь хэсгийг үзнэ үү.) Тодруулбал хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, тарчилган зовоох, тохуурхан даажигнах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэж мэдүүлэг өгөхийг албадан эрүү шүүлт тулгасан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасч, таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

*5(h) Дээд албан тушаалтнаас өгсөн тушаалын дагуу эрүүдэн шүүлт явуулахгүй байхыг тодорхой заасан хууль тогтоомжийг Оролцогч Улс санаачилсан эсэх;*

117. 2015 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 4.6 дугаар зүйлд тушаал, даалгавар биелүүлэхтэй холбогдсон зохицуулалтыг хуульчилсан. (Тайлангийн 109, 110 дахь хэсгийг үзнэ үү.)

*5(i) Айлган сүрдүүлэх хэлбэрээр сэтгэл санааны хувьд тарчилган сэтгэц мэдрэлийн хувьд эрүү шүүлт тулгах зэрэг аливаа хэлбэрээр эрүүдэх үйлдэл гаргасны төлөө, эсхүл эрүү шүүлт тулгах аливаа үйлдэлд оролцсон, уг үйлдлийг гүйцээсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх болно, ийм төрлийн үйлдэл ноцтой үр дагавартай бөгөөд ял шийтгэл хүлээлгэх үндэслэл болно гэдэг талаар цагдаагийн албан хаагч, мөрдөгч, хорих байгууллагын албан хаагчид мэдлэг, ойлголттой эсэхийг нягтлах талаар тодорхой арга хэмжээ авсан эсэх;*

118. Цагдаагийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлд баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэхэд хууль дээдлэх, хүнлэг ёс, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх зарчмыг баримтлахын зэрэгцээ баривчлагдсан, цагдан хоригдсон этгээдэд эрүү шүүлт тулгах, эсхүл бусад арга хэрэглэн түүний бие махбодийг тарчлаан зовоох буюу сэтгэл санааны дарамтад оруулахыг хориглож хуульчилсан.

119. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 251 дүгээр зүйлийн 251.1.5–д хоригдолтой хүнлэг бус, хэрцгий, нэр төрийг нь гутаан доромжилж харьцахыг хорих анги, хорих ангийн алба хаагчдад хориглосон.

120. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/183 тушаалаар баталсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм”-ийн 2.1–д “алба хаагч нь дараахь сахилга ёс зүйн хэм хэмжээг чанд сахин ажиллана”, 2.1.6–д “ялтан, хоригдол, хоригдсон этгээдийн нэр төрийг гутаан доромжлох, хүнлэг бус хэрцгий хандах, хуульд заасан үндэслэл, журмаас гадуур бие махбодид нь хүч хэрэглэхгүй байх”, 6.1–д “Зөрчил гаргасан алба хаагчид Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулна” гэж тус тус заасныг баримтлан ажиллаж байна.

121. Хорих эмнэлгийг мэргэжил, арга зүйн удирдлага, боловсон хүчнээр хангах



үүргийг Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хүлээнэ.<sup>35</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 207 дугаар зүйлийн 207.4-т зааснаар Истанбулын протоколын дагуухорих ангид шинээр ирж байгаа эрхээ хязгаарлуулсан этгээдийг эмч хүлээн авч биеийн үзлэг хийнэ. Үзлэгээр тухайн хүнд эрүү шүүлт тулгасан эсэх, айлган сүрдүүлж дарамталсан эсэх, сэтгэл зүйн нөхцөл болон биеийн эрүүл мэндийн байдлыг хянана. Улмаар сэтгэл санааны хувьд дарамтад оруулсан, тарчилгасан эсэх талаарх дүгнэлт гаргана. Энэ нь аливаа хэлбэрээр эрүү шүүлт тулгах үйлдэл гарсан эсэхийг тогтоох, уг үйлдэл ноцтой үр дагавартай бөгөөд тухайн үйлдэлд ял шийтгэл хүлээлгэх боломжийг нэмэгдүүлэх эерэг талтай.

122. Алба хаагчдын хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, үйл ажиллагаанд хүний эрхийн хандлага, арга зүйг төлөвшүүлэх, алба хаагчдаар дамжуулан хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг тогтмол зохион байгуулсны дүнд эрүү шүүлт тулгасан аливаа үйлдэлд, тэр дундаа заналхийлэх хэлбэрээр бие махбодид эрүү шүүлт тулгах аливаа үйлдэлд оролцох, хамтрах зэрэгт хариуцлага тооцдог талаар алба хаагчид ойлголттой болсоор байна. Байгууллагууд өөрсдийн түвшинд сургалтууд явуулж байгаа боловч тусгай чиг үүргээ хэрэгжүүлэхэд энэ чиглэлийн сургалт дутагдалтай байсаар байна. Сургалтын агуулгын хувьд Хороотой хамтарч ажиллах, алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхийн тулд дагнасан сургалтуудад тэднийг хамруулах хэрэгцээ байна.

*5(j)–Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 25.1(2) дагуу байцаалтад зориулсан өрөөнүүдэд зөвшөөрөл олгох зорилгоор төвийн болон орон нутгийн цагдаагийн байран дахь 82 өрөөг оруулан улс даяар тархан байрласан цагдаагийн нэгжүүд дэх 168 өрөөг нягтлан шалгасан эсэх, Оролцогч Улсаас ирүүлсэн нэмэлт тайлбар (follow-up reply) бүхий хариу бичигт тухайн үед 25 өрөөг ийнхүү шалгасан талаар дурдсан байсан; байцаалтад зориулан тохижуулсан гэдэг нь гэрчлэгдэн шалгагдсан өрөөний тоо, хаалттай холболт бүхий телевизор, видео болон аудио бичлэгийн төхөөрөмж бүхий өрөөний тоо; хариуцагчид ямар нэг төлбөр оногдуулахгүйгээр хариуцагч, мөн түүний хуульч эдгээр төхөөрөмжийг ашиглан хийгдсэн бичлэгийг олж үзэх боломжоор хангагдсан эсэх, үүнийг магадгүй шүүх хуралд нотлох баримтаар ашигласан байж болзошгүй тоо.*

123. 2017 оны 06 дугаар сарын 09–ний өдөр батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд “Баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг 2023 оны 01 дүгээр сарын 01–ний өдрийг хүртэл хугацаанд нийслэлд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, аймаг, суманд цагдаагийн байгууллага гүйцэтгэнэ” гэж заасны дагуу баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг аймаг, суманд цагдаагийн байгууллага гүйцэтгэж байна.

124. Цагдаагийн байгууллага баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх чиг үүргийг 2023 оноос өмнө үе шаттайгаар шүүхийн шийдвэр биелүүлэх

---

<sup>35</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 203 дугаар зүйлийн 203.5 дахь хэсэг

байгууллагад шилжүүлэх зохицуулалтыг дээрх хуулийн заалтад нэмэлтээр оруулсан<sup>36</sup>. Энэ шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа стандартын шаардлага хангахгүй байруудын үйл ажиллагааг цагдаагийн байгууллагаас зогсоох боломжийг олгож байгаагаар ач холбогдолтой, улмаар хуульд заасан хугацаа болоход Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага чиг үүргийг шилжүүлэн авч стандартын шаардлага хангасан байранд шийдвэрийг хэрэгжүүлэх болно.

125. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 29 цагдан хорих байрнаас 2016 оноос өмнө 11, 2016 оноос хойш 9, нийт 20 цагдан хорих байрыг барьсан. Үүнээс 8 цагдан хорих байрыг байцаалтад зориулан тохижуулах шаардлагад нийцүүлэн засварласан.

126. Цагдан хорих байрны орчин, нөхцөлийг сайжруулах урсгал завсарт 2016 оноос хойш 3.118.306.478 сая төгрөг (1.104.154 ам.доллар<sup>37</sup>), шинээр цагдан хорих байр барих барилгын ажилд 11.691.849.322 сая төгрөг (4.139.939 ам.доллар)–ийн төсвийг баталсан. Шинээр баригдсан болон урсгал засвар, тохижилт хийгдсэн цагдан хорих байрууд НҮБ–аас баталсан “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”–ийн 9 дүгээр зүйлд заасан хорих өрөө, тасалгаанд тавигдах үндсэн шаардлагыг бүрэн хангаж байна.

127. Аливаа хүнд эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар нэр төрийг нь доромжлон харьцах, хүний нэр төр, алдар хүнд, бие махбодь, сэтгэл санаанд хохирол учруулах зорилгоор мэдүүлэг авах өрөөг тусгайлан байгуулах, ашиглахыг хориглосон.

128. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 25.1 дүгээр зүйлд зааснаар<sup>38</sup> Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2017 оны А/57 дугаар тушаалаар<sup>39</sup> “Мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлага”–ыг баталсныг мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагууд үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Тус шаардлага нь гэрч, хохирогч, шинжээч, сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авах, нүүрэлдүүлэн байцаах, таньж олуулах зэрэг мөрдөн шалгах ажиллагааны хэвийн явагдах нөхцлийг бүрдүүлэх, эрүү шүүлт, хүнлэг бус харьцаанаас ангид байх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, аюулгүй байдлыг хангахад чиглэгдэж байгаа. Энэхүү шаардлагад зааснаар мэдүүлэг авах өрөөг дууны, дүрсний, дуу–дүрсний бичлэгээр бэхжүүлэх төхөөрөмж, хяналтын системээр тоногдсон нь эрүү шүүлт, хүнлэг бус харьцаанаас ангид байх нөхцлийг бүрдүүлж байгаа болно.

129. Байцаалтад зориулан тохижуулсан өрөөнд тусгай зориулалт бүхий төхөөрөмжийг ашиглан хийгдсэн байцаалтын үеийн бичлэгийг хариуцагч, түүний өмгөөлөгч олж үзэх боломжтой. Өмгөөллийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.10–т хуульд заасан үндэслэл, журмын дагуу шаардлагатай баримт сэлтийг бэхжүүлэх, хуулбарлан авах зорилгоор зураг, дууны, дүрсний, дуу–дүрсний бичлэгийн болон бусад

<sup>36</sup> 2020 оны 01 дүгээр сарын 10–ны өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орсон.

<sup>37</sup> 2020 оны 07 дугаар сарын 01–ний өдрийн Монгол банкны зарласан ханшаар дүйцүүлэн тооцов. (1 ам.доллар=2824.16 төг)

<sup>38</sup> Байцаалт явуулахдаа видео болон аудио бичлэг хийх тоног төхөөрөмжтэй байлгах талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 25.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Мөрдөгч мэдүүлгийг мэдүүлэг авах шаардлага хангасан өрөөнд авна...” гэж заасан.

<sup>39</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 25.1 дүгээр зүйлийн 17 дахь хэсэгт “Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлагыг Улсын ерөнхий прокурор батална” гэж тус тус заасан.

техник хэрэгсэл ашиглах өмгөөлөгчийн эрхийг баталгаажуулсан.

130. Байцаалтанд зориулсан өрөөнүүдийг стандарт шаардлага хангаж байгаа эсэхийг прокурор нягтлан шалгах үүрэгтэй. Прокурорын байгууллагаас хийсэн шалгалтаар зөвшөөрөлтэй өрөөнүүдэд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдод харагдахуйц байдлаар дуу, дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулсан эсэхийг нягтлан шалгасан.

131. Мөн прокурорын байгууллагаас улс орон даяар тархан байрласан цагдаагийн нэгж дэх байцаалтад зориулсан мэдүүлэг авах 168 өрөөг хэрхэн ажиллаж байгааг нягтлан шалгасан. 2020 оны байдлаар зөвшөөрөл бүхий мэдүүлгийн өрөөний тоо 193 болсон байна.

132. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдоос хүсэлт гаргасан тохиолдолд мэдүүлэг авах үйл ажиллагааны явц байдлын талаарх дуу дүрсний бичлэгийг хуулбарлан өгөх нөхцөл боломжоор хангагдсан. Шүүгдэгч болон тэдний өмгөөлөгч нарт байцаалтын үеийн бичлэгүүд нь нээлттэй байх тухайд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.7<sup>40</sup> дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуульд заасан шүүх хуралдааны явцыг шүүх хуралдааны нарийн бичгийн дарга тэмдэглэл хөтөлж, дууны, эсхүл дуу–дүрсний бичлэгээр баталгаажуулна” гэж заасан. Өмгөөллийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.14–т шүүх хуралдааны явцыг баталгаажуулсан дуу–дүрсний бичлэгийг хуулбарлаж, хувилж авах эрхтэйг заасан. Дуу, дуу–дүрсний бичлэгийг шүүх хуралд нотлох баримтаар ашигласан тохиолдлын талаар тоон мэдээлэл байхгүй байна.

133. Мөрдөн байцаалт дуусч, уг ажиллагааны явцад бүрдүүлсэн хавтаст хэргийн материалыг хэргийн оролцогчдод, мөн шүүгдэгчид танилцуулна. Энэ талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Хавтаст хэрэгт тусгагдсан эд мөрийн баримт, мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлд тусгагдсан дууны, дүрсний, дуу–дүрсний бичлэгтэй танилцах тухай оролцогчийн хүсэлтийг мөрдөгч хангах арга хэмжээ авна” гэж заасан.

134. Мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлд тусгагдсан дууны, дүрсний, дуу–дүрсний бичлэгтэй танилцуулахад ямар нэг төлбөр, хураамж авахгүй.

135. Мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлд тусгагдсан дууны, дүрсний, дуу–дүрсний бичлэгийг шүүхэд нотлох баримт болгон ашиглах тухайд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.7<sup>41</sup> дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Мөрдөн шалгах ажиллагаа, прокурорын хянан шалгах ажиллагаа, шүүх хуралдааны тэмдэглэлд тусгагдсан нөхцөл байдал нь дууны, дүрсний, дуу–дүрсний бичлэгээс зөрсөн тохиолдолд шүүх, прокурор дууны, дүрсний, дуу–дүрсний бичлэгийг нотлох баримтаар тооцно” гэж зохицуулсан. Иймд хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтад тооцогдсон бол шүүхэд нотлох баримт болгон ашиглах боломжтой юм.

---

<sup>40</sup> Шүүх хуралдааны тэмдэглэл

<sup>41</sup> Мөрдөн шалгах ажиллагаа, прокурорын хянан шалгах ажиллагаа, шүүх хуралдааны тэмдэглэл

**Гомдлын мөрөөр шуурхай, хараат бус, үр нөлөөтэй мөрдөн шалгах нь**

*6. Хорооноос өмнө өгсөн ажиглалт дүгнэлт (17, 18 дахь параграф)–д дурдсаны дагуу 2008 оны 07 дугаар сарын 01–ний өдөр болсон үйл явдалтай холбогдуулан аливаа нэмэлт арга хэмжээ авсан талаар мэдээллийг шинэчлэн гаргаж өгнө үү. Ийнхүү гаргаж өгөхдөө эрүү шүүлт тулгасан, хүнлэг бус хэрцгий байдлаар хандсан үйлдлүүдийг үр дүнтэйгээр бие даасан байдлаар мөрдөн шалгалт явуулж чадсан эсэхийг мөн эрүү шүүлт тулгасан, хүнлэг бус хэрцгий байдлаар хандсан үйлдэл гаргагчдыг яллах, шүүх ажиллагаа явуулсан эсэхийг мэдээлэлд оруулна.*

136. 2008 оны 07 дугаар сарын 01–ний өдөр болсон үйл явдалтай холбогдуулан авсан арга хэмжээ талаар өмнөх тайланд тусгагдсан мэдээлэл хэвээр байгаа бөгөөд нэмж тусгах мэдээлэл байхгүй болно.

*7. Хорооноос өмнө өгсөн ажиглалт дүгнэлтийн дээр дурдсан хэсэг (17, 18 дахь параграф)–н дагуудараах мэдээллийг гаргаж өгнө үү  
7(а) Эрүүдэн шүүсэн үйлдлийг мөрдөн шалгах эрх хэмжээг өөр байгууллагад шилжүүлсний дүнд эрх чөлөөгөө хасуулсан хүний гаргасан гомдлын тоо буурсан эсэх;*

137. Прокурор эрүү шүүлт тулгасан гэмт хэргийг мөрдөн шалгах харьяалал тогтооно. (Тайлангийн 114 дэх хэсгийг үзнэ үү.) Монгол Улсын Ерөнхий прокурорын тушаалаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлд заасан “Эрүү шүүлт тулгах” гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгах, мөрдөн шалгах ажиллагаа явуулах харьяаллыг Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст өөрчлөн тогтоож өгсөн бөгөөд ийнхүү шилжүүлснээр гомдлын тоо буураагүй.

138. Практикт эрүү шүүлт тулгасан гэх гомдлын мөрөөр хэрэг бүртгэлтийн хэрэг үүсгэж, шалгах явцад хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр шалгагдаж байгаа хэргүүдийн 50 хувь хэрэгсэхгүй болж, шалгагдаж байгаа хэргийн 3,9 хувь нь шүүх рүү шилжиж байна.

139. Нотлох баримт үрэгдэх, үрэгдүүлсэнтэй холбоотой харилцааг зохицуулсан зохицуулалт дутмаг, хэрэг гарах үед учруулсан гэмтлийг тогтоох, нотолгоог баримтжуулах, шалгах талаарх мэдлэг гомдол гаргагчдын хувьд дутмаг байна. Иймд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх шаардлагатай байна.

140. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч шалгахад нэг талаас, гэмт хэрэгт холбогдон шалгагдаж буй хүмүүс өөрийг нь шалгаж буй мөрдөгч болон бусад албан тушаалтныг гүтгэх, өөрийн холбогдсон хэргийг шалгах ажиллагаанд саад учруулах зорилготой гомдол гаргах явдал цөөнгүй байгааг дурдах нь зүйтэй. Гэхдээ олонх нь эрүү шүүлтэд өртсөн байж болохуйц бодитой факт ярих боловч тэдний мэдүүлгийг нотлох баримт олдох нь ховор байдаг. Тодруулбал, эрүүл мэндэд учирсан гэмтэл, ул мөрийг бэхжүүлэх талаар эмч, эмнэлгийн ажилтнууд үүргээ хангалттай биелүүлдэггүй, зарим нь эрүү шүүлтийн талаар ойлголт муу байдагтай холбоотой. Эсхүл эрүү шүүлтэд өртсөн гэх хүн өөрөө эмч, эмнэлгийн байгууллагад ханддаггүй, хаана

гомдол гаргахаа мэдэхгүй хугацаа алдсанаас болж энэ төрлийн гэмт хэргийг нотлох ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг. Сэтгэл санааны эрүү шүүлт болон зүй бус харьцааны хувьд нотлоход бүр ч төвөгтэй болдог. Мэдүүлэг авах ажиллагаа явуулахад зориулсан, камерын бичлэг бүхий өрөөний хүртээмж хангалтгүй учир сэжигтэн, яллагдагч, гэрч, хохирогчийг камерын хяналтаас гадуур байцаах тохиолдол байсаар байгаа бөгөөд энэ тохиолдолд сэтгэл санааны эрүү шүүлт тулгасан, эсхүл зүй бус харьцсан нөхцөл байдлыг тогтооход хүндрэлтэй байдаг.

*7(b) Эрүү шүүлт тулгасан, хүний нэр төрийг доромжлон хүнлэг бусаар хандсан тохиолдолд мөрдөн шалгалт хийж буй байдал, энэ асуудлаар гаргасан гомдлыг хүлээж авах хараат бус бие даасан механизм уг байдлыг зогсоож буй эсэх;*

141. Энэ төрлийн гэмт хэргийн талаарх гомдлыг хүлээж авч холбогдох байгууллагад шилжүүлэх чиг үүрэгтэй хөндлөнгийн байгууллага нь Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс билээ. Гомдол хүлээн авах асуудлыг зөвхөн гишүүний бүрэн эрхийн хүрээнд авч болох арга хэмжээ байхаар өмнөх хуулиар зохицуулагдсан байсан бөгөөд ажлын албаны албан хаагчдад хамаарахгүй байсан нь гомдол хүлээн авахад хүндрэл учруулдаг байсан байна. Тухайлбал Комиссын гишүүн зөвхөн өөрийн биеэр ирсэн тохиолдолд мэдээлэл өгөх асуудал тогтмол хөндөгддөг бөгөөд үйл ажиллагаагаа хэвийн явуулах үүднээс хууль хяналтын байгууллагуудын удирдлагын түвшинд харилцан тохиролцсоны үндсэн дээр тухайн хэргийг хариуцсан Комиссын мэргэжилтэнд гишүүний зүгээс итгэмжлэл олгох байдлаар дээрх хуулийн заалтын хэрэгжилтийг хангаж байв. Хувийн хэвшлийн байгууллагуудыг шалгах, тэдгээрээс баримт, мэдээ авах нөхцөлд энэ заалтыг хэрэгжүүлэхэд ихээхэн хүндрэл учирдаг байсныг 2017 онд батлагдсан Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулиар өөрчлөхийг зорьсон болно.

142. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс нь хууль тогтоох дээд байгууллагад жил бүр хүргүүлдэг Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлд эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаар, гомдол мэдээллийн талаар дурддаг. 17, 18 дахь удаагийн илтгэлд дээрх асуудлаар дэлгэрэнгүй тайлагнасан байна.

143. Гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны тухайд Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг Комиссын гишүүн хэрэгжүүлнэ. Тухайлбал хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн, зөрчих нөхцөл бүрдүүлсэн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд шаардлага, зөвлөмж хүргүүлэх, иргэн, байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах, шүүх хуралдаанд хуулиар тогтоосон журмын дагуу биечлэн болон төлөөлөгчөө оролцуулана. Түүнчлэн хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн гэж үзсэн саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавих, талуудыг эвлэрүүлэн зуучлах, гомдол, мэдээлэл нь эрүү, зөрчлийн шинжтэй гэж үзвэл харьяаллын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх, зөрчлийг арилгах үүрэг бүхий байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд зөрчил арилгуулахаар гомдол, мэдээллийг шилжүүлэх, биелэлтийг шаардах, эрүү шүүлт явуулсан байж болзошгүй албан хаагчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх асуудлыг Улсын ерөнхий прокурорт

уламжлах зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Комиссын гишүүн гомдол, мэдээллийг хэрхэн шийдвэрлэсэн талаар хуульд заасан журмын дагуу гомдол, мэдээлэл гаргагчид хариу мэдэгдэнэ.

*7(с)–Гомдол гаргасан тохиолдолд сэтгэл санааны, бие махбодийн, сахилгын болон захиргааны аргаар тарчилгахаас гомдол гаргагч, түүний хуульч болон уг байдлыг гэрчлэх хүмүүсийг хамгаалах талаар авсан тодорхой арга хэмжээнүүд.*

144. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.3 дугаар зүйлд заасны дагуу гэмт хэргийн хохирогч, хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг тэдний аюулгүй байдлын хангахтай холбоотой мэдээллээр хангах үүргийг мөрдөгч, прокурорт хариуцуулсан.

145. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Арван гуравдугаар бүлэгт Гэрч хохирогчийг хамгаалах асуудлыг зохицуулсан. Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах шийдвэрийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд мөрдөгчийн санал, гэрч, хохирогч, өмгөөлөгчийн хүсэлт, шүүхийн шатанд прокурорын санал, гэрч, хохирогч, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэж шийдвэрлэдэг.

146. 2013 онд батлагдсан Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиар хэрэгт оролцож байгаа хохирогч, гэрчүүд нь хуулийн дагуу эрхээ хамгаалуулна. Тодруулбал “гэмт хэрэг хянан шийдвэрлэх явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх эрх зүйн үндсийг тогтоох”–д чиглэсэн. Уг хуулийн зохицуулалтад хамаарах этгээдэд “1/гэрч, хохирогч, 2/шаардлагатай гэж үзвэл гэрч, хохирогчийн хамаарал бүхий этгээд<sup>42</sup>, 3/гэмт хэрэг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл, баримт сэлт өгөх болон бусад байдлаар туслалцаа үзүүлсэн, гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчээр оролцоогүй хүн энэ хуульд хамаарагдаж болно” гэж зохицуулсан болно.

147. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.9 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт гэрч хохирогчийг дарамталсан, айлган сүрдүүлсэн тохиолдолд яллагдагчийг цагдан хорих үндэслэл болгож тусгасан. Томилогдсон өмгөөлөгчийг оролцуулах, хэргийн бусад оролцогчийг өмгөөлөх эрхээр хангах боломжийг зааж өгсөн.

### **Хүний эрхийн үндэсний байгууллага, үндэсний урьдчилан сэргийлэх механизм**

*8. Хорооноос өмнө өгсөн ажиглалт дүгнэлт (33, 34 дэх параграф)–ийн дагуу дараах мэдээллийг гаргаж өгнө үү.*

*8(а)–Тус Конвенцийн нэмэлт Протоколын дагуу байгуулагдах ёстой үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг бий болгоход Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисст уг чиг үүргийг өгөх талаар зохицуулалт хуульд оруулсан эсэх;*

<sup>42</sup> Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйл /Хуулийн зохицуулалтад хамаарах этгээд/–ийн 5.3–д “...гэрч, хохирогчийн хамаарал бүхий этгээд гэж тэдгээрийн нөхөр /эхнэр/, хамтран амьдрагч, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар болон үрчилж авсан хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охиныг ойлгоно.”

148. Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр баталсан. Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуульд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизмыг бий болгох талаар тусгасан. (Тайлангийн 8, 9 дэх хэсгийг үзнэ үү.)

*8(b)–Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс нь хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих үндэсний байгууллагын статустай холбоотой зарчмуудын (Парисын зарчмууд) дагуу үйл ажиллагаагаа хараат бусаар, үр дүнтэй явуулах эрх хэмжээ бүхий хангалттай санхүүгийн болон хүний нөөцөөр хангагдсан эсэх мөн зохих бүтэцтэй болсон эсэх;*

149. Шинэчлэн батлагдсан Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуульд Комиссын 5 гишүүнээс гадна эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хараат бус үйл ажиллагаа явуулах 1 гишүүн ажиллана. Түүнд дэмжлэг үзүүлэн ажиллах нэгжийн чиг үүргийг хуульд тусгасан ба уг гишүүн нь аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт, тодруулбал хорих байгууллага, цагдан хорих анги, баривчлах байр /төв/, түр болон албадан саатуулах газар, хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон ахмадын асрамжийн газар, сургуулийн дотуур байр, албадан эмчилгээний байр, дүрвэгсдийн байр, цэргийн сахилгын байр, хилийн шалган нэвтрүүлэх боомт дахь түр саатуулах байр, сэтгэцийн эмнэлэг зэрэгт аль ч цаг үед саадгүй нэвтрэх, хяналт шинжилгээ хийх, нөхцөл байдлыг техник хэрэгсэл ашиглан баримтжуулах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулахаар шилжүүлж, олон нийтэд мэдээлэх чиг үүрэгтэй байхаар тусгасан.

150. Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль шинэчлэгдэн батлагдсанаар Парисын зарчмуудын дагуу үйл ажиллагаагаа хараат бусаар, үр дүнтэй явуулах эрх хэмжээ бүхий хангалттай хүний нөөцөөр хангагдах эрх зүйн үндэслэл бий болсон. 2020 оны 3 дугаар улирлын байдлаар Комиссын 5 гишүүн үүрэгт ажилдаа орсон байна. Харин эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан 1 гишүүнийг сонгон шалгаруулах ажил дуусаагүй байна.

*8(c)–Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Дэд хорооноос гаргасан үндэсний урьдчилан сэргийлэх механизмын талаарх удирдамж болон Нэмэлт Протоколд тусгасан шаардлагуудыг бүрэн тусгасан эсэх, үндэсний урьдчилан сэргийлэх механизмд чиг үүргийн болон үйл ажиллагаагаа хараат бусаар явуулах боломж олгосон хууль батлах замаар Конвенцийн нэмэлт Протоколын дагуу хүлээсэн үүрэгт нийцүүлэн Оролцогч Улсын зүгээс хийсэн ажлын явц, одоогийн байдал.*

151. (Тайлангийн 148, 149 дэх хэсгийг үзнэ үү.) Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн 12 дугаар зүлийн 12.1.2–т зааснаар эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хараат бус үйл ажиллагаагаа явуулах гишүүнийг сонгон шалгаруулах журмыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо баталсан. Тус журамд гишүүнд нэр дэвшигчдийг

сонгон шалгаруулалт явуулах үе шат, зарыг нийтэд мэдээлэх, холбогдох Ажлын хэсэг байгуулах, нэр дэвшигч хүсэлт гаргах, оролцогчоор бүртгэх, оролцогчийн талаарх мэдээлэл цуглуулах, томилгооны сонсгол зохион байгуулах, гишүүнийг сонгон шалгаруулж, нэр дэвшүүлэхтэй холбоотой зохицуулалтыг тусгасан.

152. Дээрх журмын дагуу 2020 оны 04 дүгээр сарын 15–наас 05 дугаар сарын 15–ны өдрийн хооронд Хүний эрхийн үндэсний комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний сонгон шалгаруулалтад нэр дэвших хүсэлтэй иргэдийг хүсэлтийг хүлээн авсан. Нэрсийг parliament.mn вэб сайт дээр 2020 оны 05 дугаар сарын 26–ны өдрөөс нээлттэй байршуулсан.

153. Дээр дурдсан журмын 1.9, 9.2–т заасны дагуу сонсголыг 2020 оны 6 дугаар сарын 10, 11–ний өдрүүдэд явуулсан. 19 оролцогчийг хүсэлт ирүүлсэн дарааллын дагуу сонсгол явуулсан болно. Сонсголыг олон нийтэд нээлттэй явуулсан бөгөөд олон нийтийн оролцоог хангах үүднээс цахим хэлбэрээр тэдний оролцоог хангаж, сонирхсон асуулт тавьж, хариулт авах боломжоор бүрэн хангасан.

155. Эрүү шүүлтийн эсрэг үндэсний механизмыг бий болгож, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хараат бус үйл ажиллагаагаа явуулах гишүүн болон нэгжийн чиг үүргийг дээрх хуульд тусгасан. Тус нэгжид удирдах 1 ажилтан буюу комиссараас гадна гүйцэтгэх 7 албан хаагч, үйлчлэх 3 ажилтны орон тоог баталсан байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд зааснаар Комисс нь улсын төсвөөс санхүүжих, Комиссын төсөв нь үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байх ёстой. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийг хэрэгжүүлэх тэр дундаа Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг үр дүнтэй ажиллуулахтай холбогдох зардлыг 339,134,850 төгрөг (ойролцоогоор 119,011.80 ам.доллар)–г 2021 оны улсын төсөвт тусгасан. Иймд санхүүгийн хувьд үйл ажиллагаа явуулах нөхцөл хангагдсан болно.

### **Насанд хүрээгүй этгээдийг шүүх ажиллагаа**

*9. Хорооноос өмнө өгсөн ажиглалт дүгнэлт (23, 24 дэх параграф)–ийн дагуу дараах мэдээллийг шинэчлэн гаргаж өгнө үү.*

*9(а)–Олон улсын стандартад нийцсэн насанд хүрээгүй хүнийг шүүх үр дүнтэй, тусгайлсан, тасралтгүй ажиллах шударга ёсны тогтолцоог бий болгох талаар авсан аливаа тодорхой арга хэмжээ;*

156. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно...” гэж заасан.

157. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Арван наймдугаар бүлэгт Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн үйлдсэн гэмт хэрэгт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах журмыг хуульчилсан.

158. Шүүх өсвөр насны шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах, шийдвэр гаргахдаа түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангахын зэрэгцээ



өсвөр насны шүүгдэгчтэй харьцахдаа түүний нэр төрийг хүндэтгэн харьцаж, насны онцлогийг харгалзан хүмүүжих, алдаагаа засах боломж олгохыг анхаарч ажиллана. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хаалттай явуулж, шийдвэрийг олон нийтэд мэдээлэхдээ өсвөр насны шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, түүнд учирч болох бусад хор уршгийг тусгайлан харгалзах, өсвөр насны шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг энэ хуульд заасан ердийн журмаар явагдах ажиллагаанаас шуурхай, богино хугацаанд явуулах нөхцөлийг шүүх хангаж ажиллах зэргээр тус ажиллагаанд баримтлах нийтлэг шаардлагыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан.

159. Эрүүгийн хэргээс өсвөр насны яллагдагчид холбогдох хэргийг мөрдөн байцаалтын шатанд тусгаарлаж шалгана. Өсвөр насны яллагдагчийн хэргийг тусгаарлах нь хэргийг бүх талаас нь бүрэн бодитой тогтооход саад учруулахаар байвал тусгаарлахгүй байж болно.

160. Өсвөр насны яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авах шүүхийн хэлэлцүүлэг хаалттай явагдах ба өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгчийг оролцуулна. Өсвөр насны яллагдагчид хавтаст хэргийн материалыг хуульд заасны дагуу танилцуулахад түүний өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгчийг оролцуулна.

161. Өсвөр насны шүүгдэгчийн хууль ёсны төлөөлөгч шүүх хуралдааны туршид байлцана. Шүүх хуралдааны явцад өсвөр насны шүүгдэгчид сөргөөр нөлөөлж болох байдал тогтоогдвол талуудын хүсэлтээр шүүх хуралдаан даргалагч түүнийг шүүх хуралдааны танхимаас гаргаж болно.

162. 2016 онд батлагдсан Хүүхэд хамгааллын тухай хуульд гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог аймаг, дүүрэг тус бүрт ажиллуулахаар заасан. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/51, А/69 дугаар хамтарсан тушаалаар баталсан.

163. Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2017 оны 114 дүгээр тушаалаар “Эрүүгийн эрх зүйн хууль тогтоомжийн шинэтгэл” сургалтын хөтөлбөрийг баталсан. Тус хөтөлбөрт “Өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх” гэсэн агуулгыг багтаасан бөгөөд хөтөлбөрийн дагуу сургалтыг 2017 оны 10, 11 дүгээр сард 3 ээлжээр зохион байгуулж, эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн нийт 193 шүүгчийг оролцуулсан.

164. 2017 онд Улаанбаатар хотын төвийн 3 дүүрэгт гэр бүлийн хэрэг, маргааныг төвлөрүүлэн шийдвэрлэх ажиллагааны онцлогт нийцүүлж орчин нөхцөлийг бүрдүүлсэн. Эдгээр шүүхийн байрны шүүх хуралдааны танхим, уулзалтын өрөө нь гэр бүлийн дагнасан шүүхтэй бусад улсын туршлагыг нэвтрүүлсэн хүүхдийн эрх ашгийг хамгаалах боломжийг бүрдүүлсэн өрөө, танхимтай болсон.

165. Тайлангийн хугацаанд улсын төсвийн 166 сая төгрөгийн хөрөнгөөр хүүхдээс мэдүүлэг авах жишиг өрөөг аймаг, дүүргийн цагдаагийн 30 хэлтэст байгуулж, ашиглалтад

оруулав.

166. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2019 оноос Гэр бүл, өсвөр насны хүний хэргийн төрөлжсөн шүүх байгуулах хэрэгцээ шаардлагын тандан судалгааг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж байна.

167. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтыг 2019 оны 12 дугаар сарын 09–нөөс 18–ны өдрүүдэд бүсчилсэн байдлаар зохион байгуулж, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны 270 гишүүдийг сургасан. Сургалтад зориулсан гарын авлага боловсруулан холбогдох албан хаагчдад тараасан.

*9 (с) Таслан сэргийлэх арга хэмжээний хувьд өсвөр насны хүнийг цагдан хорих арга хэмжээ нь хуульд заасанд нийцүүлсэн авч болох сүүлийн арга хэмжээ байдаг эсэх, тэднийг насанд хүрсэн хүмүүсээс тусад нь байлгах, хамгийн боломжит бага хугацаагаар уг арга хэмжээг авах, ийнхүү таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан өсвөр насны хүмүүсийн нөхцөлийг хараат бусаар тогтмол хянаж байдаг эсэх;*

168. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18.8 дугаар зүйлээр өсвөр насны хүнийг цагдах хорих харилцааг зохицуулсан. Өсвөр насны яллагдагчийг цагдан хорих үндсэн хугацаа 1 сар байх ба цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний нийт хугацаа Эрүүгийн хуульд хорих ялын дээд хэмжээг 5 жил хүртэл хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэргийн яллагдагчид 3 сараас, Эрүүгийн хуульд хорих ялын дээд хэмжээг 5 жилээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэргийн яллагдагчид 6 сараас хэтэрч болохгүй.

169. Өсвөр насны яллагдагч, хөхүүл хүүхэдтэй эмэгтэй яллагдагчид Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.11 зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан, оргон зайлсан, шүүгч прокурор, мөрдөгч хохирогч, гэрч, шинжээч, гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, сүрдүүлсэн, эсхүл тэдгээрийн болон өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах дахин гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэрэг үйлдэж болзошгүй талаар үндэслэл бүхий баримт мэдээлэл байгаа, урьд авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, шүүх прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй” тохиолдлоос бусад тохиолдолд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болохгүй талаар зохицуулсан ба өсвөр насны хүнд дээр дурдсанаас өөр үндэслэлээр цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан тохиолдол байхгүй байна.

170. Өсвөр насны хүнд авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг Шүүхийн шийдвэрийн дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангид 26 өрөөнд, орон нутаг дахь цагдан хорих байранд тус бүр 1 хорих өрөөнд өсвөр насны яллагдагчид авсан таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

171. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2014 оны А/209 дүгээр тушаалаар батлагдсан “Хорих байрны дотоод журам”-ын 3.1–т Баривчлагдсан, цагдан хоригдсон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг хорих өрөөнд хуваарилахдаа Сэжигтэн яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийг

мөрдлөг болгоно гэж тус тус заасныг хэрэгжүүлж, өсвөр насны хүний хорих байрыг ахуйн өхцөлийн хувьд сайжруулан тохижуулсан өрөөнд байрлуулж, хоолны илчлэгийн хэмжээг нэмэгдүүлэн, нэмэлт хоол хүнсээр хангаж байна. Өсвөр насны хүмүүсийн харуул хамгаалалтыг тусад нь өсвөр насны хүмүүс хариуцсан ажилтнууд ажиллуулан хяналтыг хэрэгжүүлж байна.

172. Таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан өсвөр насны хүмүүсийн хоригдож буй нөхцөл байдалд прокурорын болон хүний эрхийн бусад байгууллагууд тогтмол хяналт тавьж ажилладаг. Өнөөдрийн байдлаар цагдан хорих байранд хоригдож буй өсвөр насны хүмүүсийг насанд хүрсэн хүнтэй хамт хорьсон зөрчил гараагүй.

*9 (d) Баянзүрх дүүрэг дэх гэмт хэрэг, зөрчилд холбогдсон өсвөр насны хүнд зориулсан тусгай сургалт, боловсрол олгох төвийн барилга 2017 онд бүрэн ашиглалтад орно гэсэн төлөвлөгөөний дагуу баригдаж дууссан эсэх.*

173. Засгийн газрын 2017 оны 204 дүгээр тогтоолоор “Хорих байгууллага, түүний нутаг дэвсгэрийн байршил, хорих ангийн дэглэм”-ийг баталсан бөгөөд өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд хаалттай 5, нээлттэй 7, нээлттэй, хаалттай дэглэмтэй 5 хорих анги, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага 1, эмнэлэг 2, эмэгтэйчүүдийн хорих анги 1, нийт 21 хорих анги, баривчлах төв 1, баривчлах байр 1, Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх газар 1, Нийслэлд цагдан хорих төв 1, орон нутагт 28 цагдан хорих байртайгаар үйл ажиллагаа явуулж байна.

174. Нийслэлд баривчлах төвийн багтаамж хэтэрч баривчлах шийтгэлээр шийтгүүлсэн этгээдийг ачааллыг багасгах зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн “Баривчлах байр байгуулах тухай” А/21 дүгээр тушаалын дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн “Баривчлах байрны бүтэц, орон тоог батлах тухай” А/30 дугаар тушаалаар бүтэц орон тоог баталсан. Үүний дагуу арга хэмжээ авснаар баривчлах төвд ачаалал үүсэхгүй болсон.

175. Баянзүрх дүүрэг дэх гэмт хэрэг, зөрчилд холбогдсон өсвөр насны хүнд зориулсан тусгай сургалт, боловсрол олгох төвийн барилга буюу Баянзүрх дүүргийн 21 дүгээр хороонд байрлах 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн дэргэд нийт 4 давхар, 2500м<sup>2</sup> шинэ барилгыг ашиглалтад бүрэн оруулсан.

### **3 дугаар зүйл**

#### **Дүрвэгсдийг албадан гаргахгүй байх**

10. Хорооноос өмнө өгсөн ажиглалт дүгнэлт (35, 36 дахь параграф)-н дагуу дараах мэдээллийг шинэчлэн гаргаж өгнө үү.

*10(a) – Конвенцийн 3 дугаар зүйлийн дагуу буцаан өгөхгүй байхтай холбоотой үүргээ биелүүлэхийн тулд хууль тогтоох, шүүхийн болон захиргааны арга хэмжээ Орлолцогч Улс авсан эсэх;*

176. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Дөчин хоёрдугаар бүлэгт “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагаа”, Дөчин гуравдугаар дугаар бүлэгт “Тогтоол биелүүлэх зорилгоор хүнийг шилжүүлэн авах, шилжүүлэн өгөх”, Дөчин дөрөвдүгээр бүлэгт “Хорих ял шийтгүүлсэн хүнийг харьяат улсад нь ял эдлүүлэхээр шилжүүлэх, Монгол Улсын иргэнийг шилжүүлэн авах” ажиллагааг тусгайлан зохицуулснаас гадна Прокурорын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт “Прокурорын төв байгууллага нь олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол эрүүгийн хэргийн талаарх ажиллагааг хариуцан зохион байгуулах төв байгууллага байна” гэж заасан.

177. Бусад улсуудтай байгуулсан эрх зүйн туслалцааны гэрээнд тухайн шилжүүлэн өгөх гэмт хэрэгт оногдуулах боломжтой ялын доод хязгаар нь 1 жил байх талаар заасан. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуулийн 1.7 дугаар зүйлд гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэх зохицуулалтыг тусгасан.

178. Эрүүгийн хуулийн 1.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Тухайн улсын хуульд зааснаар цаазаар авах ял оногдуулах, эрүү шүүлт тулгах хангалттай үндэслэл байгаа тохиолдолд гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг тухайн улсад гэмт хэрэгт мөрдөн шалгуулах, ял шийтгүүлэхээр шилжүүлэн өгөхгүй” гэж заасан.

179. Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх, гэмт этгээдийг шилжүүлэх ажиллагааны талаар олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргийг биелүүлэх, олон улсын жишиг стандарт, хэм хэмжээнд заасан шаардлагыг хангахын тодорхой ажлуудыг хийж байна.

180. Тодорхой ажлууд гэдэгт: 1/ Дотоодын холбогдох байгууллагуудын хоорондын уялдааг сайжруулах; 2/ Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх, гэмт этгээдийг шилжүүлэхтэй холбогдсон гэрээ, хэлэлцээрийн албан ёсны эх сурвалж, түүнчлэн хүсэлт, түүний гүйцэтгэл, явц байдлын талаарх тоо баримтууд, холбогдох мэдээлэл бүхий “Мэдээллийн цахим сан”-тай болох; 3/ Холбогдох байгууллагуудын албан хаагчдыг мэргэшүүлсэн сургалтуудыг зохион байгуулах зэрэг болно.

*10(b) – Шилжүүлэх, буцаах тухай мэдээлэл өгөхөд хөөгдөн гарч байгаа хувь хүмүүс албадан гаргах шийдвэрийг давж заалдаж, шүүхэд гомдол гаргаж байгаа эсэх, эсхүл орогнол хүсэх эрхээ эдэлж байгаа эсэх, ийнхүү гаргасан шийдвэрийг давж гомдол гаргасан нь шийдвэрийг түдгэлзүүлэхэд нөлөө үзүүлдэг эсэх; тайлангийн хугацаанд хүлээж авсан орогнол хүссэн өргөдлийн тоо, зохих ёсоор амжилттай гаргасан өргөдлийн тоо, өөрийн улсад хэрэв очвол эрүүдэн шүүгдэх боломжтой гэж үзсэний улмаас өргөдлийг нь хүлээж авсан орогнол хүсэгчдийн тоо;*

181. Эрүүгийн хуулийн 44.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын шүүхээр хорих ял шийтгүүлсэн хүнийг харьяат улсад нь шилжүүлэн өгөх шийдвэрийг Улсын ерөнхий прокурор гаргаж, түүнийг шийдвэр гаргасан шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад мэдэгдэнэ” гэж заасан.

182. Прокурорын байгууллага гадаадын бусад улс оронтой Монгол Улсын нэгдэн

орсон олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэгт холбогдсон хүнийг шилжүүлэх авах, өгөх, хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэх өгөх, авах хэлбэрээр хамтран ажиллах бөгөөд уг ажиллагааг Улсын Ерөнхий прокурорын газар хариуцан зохион байгуулдаг.

183. Олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаад улсаас эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа авахаар ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч бүртгэн, олон улсын гэрээ, Монгол Улсын хууль тогтоомжийн шаардлагад нийцсэн тохиолдолд хүсэлтийн агуулга, гүйцэтгэх ажиллагааг харгалзан хяналт тавих прокурорын газар, мөрдөн шалгах чиг үүрэг бүхий байгууллагын харьяалал, гүйцэтгэх хугацааг прокурорын тогтоолоор тогтоож, биелэлтийг хангуулан ажиллаж байна.

184. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэгт “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах тухай шийдвэрийг гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дарга гаргана” гэж заасан бөгөөд гадаадын иргэнийг албадан гаргах ажиллагаанд шүүх оролцдоггүй. Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах шийдвэрийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга гаргах бөгөөд уг шийдвэр нь төрийн захиргааны алба хаагчийн гаргасан шийдвэр болохын хувьд Захиргааны ерөнхий хуульд заасан захиргааны шийдвэрт хамаарах бөгөөд Захиргааны хэргийн шүүхийн хяналтад багтана.

185. Монгол Улс нь НҮБ-ын Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай Конвенцид нэгдэж ороогүй. Иймд орогнол хүсэгч болон дүрвэгсдийн оршин суух асуудлыг бусад гадаадын иргэний нэгэн адил Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын виз олгох журам”-ын дагуу зохицуулж байна.

186. НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Дээд комиссарын газарт хандан орогнол хүссэн, дүрвэх хүсэлт гаргасан гадаадын иргэд хилээр орж ирснээсээ хойш 7 хоногийн дотор болон тус улсад оршин суух хугацаагаа дуусахаас өмнө НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газрын Монгол Улс дахь Төлөөлөгчийн газарт дүрвэгсдийн статус авах хүсэлт гаргана. Уг хүсэлтийг харгалзан Монгол Улсад оршин суух зөвшөөрлийг 6 сараас 1 жилийн хугацаагаар Гадаадын иргэн, харьяатын газар олгоно. Төлөөлөгчийн газар статусыг сунгах тохиолдолд хүсэлт гаргасан хугацаагаар сунгана. Энэ хугацаа нь Монгол Улсад ирээд гуравдагч улс руу дүрвэн гарахад хангалттай хугацаанд тооцогддог. Энэ хугацаанд тэд гадаадын иргэдийн адил эрх эдэлж, үүрэг хүлээдэг.

187. НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газрын Монгол Улс дахь Төлөөлөгчийн газраас Монгол Улсад түр ирэгчийн статусаар орж ирээд гуравдагч аль нэг улс руу дүрвэх хүсэлт гаргасан гадаадын иргэний визийн асуудлыг хугацаанд нь зохих байгууллагад ирүүлдэггүй, НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Дээд комиссарын газарт хандан орогнол хүссэн, дүрвэх хүсэлт гаргасан гадаадын иргэд хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийг хугацаанд нь авдаггүйгээс дотоодын хууль тогтоомжийн дагуу торгууль ногдуулдаг болно.

188. Гадаадын иргэнийг албадан гаргах болон шилжүүлэн өгөх ажиллагаанд шүүх

оролцдоггүй, шүүхийн шийдвэр гардаггүй. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Дөчин дөрөвдүгээр бүлэгт заасан журмын дагуу ялтан шилжүүлэн өгөх, авах асуудлыг шүүх хянан шийдвэрлэх бөгөөд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсэгт заасны дагуу гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах нь улс хооронд ялтан шилжүүлэх асуудалд үл хамаарна.

*10(с)–Хүнийг эрүү шүүлтэд өртөх аюул тулгарч магадгүй улс орон руу шилжүүлэх, буцаах, албадан гаргахгүй байхыг нягтлах талаар авсан тодорхой арга хэмжээ авсан эсэх; тайлангийн хугацаанд шилжүүлсэн, буцаасан, албадан гаргасан хүний тоо, буцаан өгсөн улс орны жагсаалт, буцаагдсан үндэслэл, эх оронд нь буцаасан хүмүүсийг нас, хүйсээр нарийвчлан гаргах; одоо байгаа гомдол гаргах механизм; гомдол гаргасны үр дүн, давж заалдсаны эцсийн үр дүн;*

189. Гадаадын иргэнийг өөрийн улсаас албадан гаргаж, аливаа улсад шилжүүлэн өгөх үед онцгой анхаарах ёстой хоёр зүйл нь цаазаар авах ял шийтгүүлэх болон эрүү шүүлтэд өртөх эрсдэл байгаа эсэхийг нягтлахтай холбоотойгоор бүртгэлийн асуудлыг боловсронгуй болгохоор Монгол Улсын Засгийн газрын 2020–2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.9–д “гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно” гэж тусгасан. (Тайлангийн 184 дэх хэсгийг үзнэ үү.) 2016 онд 27 орны 450 гадаадын иргэн, 2017 онд 32 орны 367 гадаадын иргэн, 1 харьяалалгүй хүн, 2018 онд 28 орны 530 гадаадын иргэн, 2 харьяалалгүй хүн, 2019 онд 26 орны 1509 гадаадын иргэн, 1 харьяалалгүй хүнийг тус Монгол Улсаас албадан гаргасан.

190. Монгол Улсаас албадан гаргах тухай шийдвэртэй холбогдуулан дараах байдлаар гомдол гаргаж шийдвэрлүүлэх боломжтой: 1/Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар “Гомдлыг түүнд холбогдож байгаа байгууллага, албан тушаалтныг харьяалсан дээд шатны байгууллага, албан тушаалтанд гаргана”; 2/ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1–д заасны дагуу хуульд өөрөөр заагаагүй, захиргааны үйл ажиллагаанд гомдол гаргах ажиллагаа Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу явагдсан бол дараахь тохиолдолд шийдвэрийг мэдэгдсэнээс хойш захиргааны хэргийн шүүхэд 30 хоногийн дотор нэхэмжлэл гаргана.

191. Захиргааны хэргийн шүүхээс уг гомдлыг хянан хэлэлцээд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 61 дүгээр зүйлд зааснаар захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлдэг.

192. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62 дугаар зүйл, эсхүл хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүгч хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр захиргааны актын биелэлтийг зөвхөн хуульд заасан үндэслэлээр түдгэлзүүлнэ, уг түдгэлзүүлсэн шүүгчийн захирамж нь тухайн хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл хүчин төгөлдөр байна.

*10(d)–Хүний эрх болон олон улсын дүрвэгсдийн эрх зүйн асуудлаар мөн Конвенцийн зүйл, заалтуудын талаар аливаа сургалтыг хууль сахиулах байгууллагын албан хаагчид болон шилжүүлэн өгөхөөс татгалзах зарчмыг харгалзан үзэж байх ёстой цагаачлалын асуудал хариуцсан албан хаагчдад зориулан явуулсан эсэх; Оролцогч улс нь буцаан өгөхгүй байх талаар хүлээсэн үүргээ тодорхойлохдоо хувь хүн бүрт холбогдох хэргийг нэг бүрчлэн шатлан үнэлдэг (assesses the merits of each individual case) эсэх;*

193. Монгол Улсын Гадаад харилцааны яам, НҮБ–ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Дээд комиссарын албатай хамтран 2019 оны 12 дугаар сарын 10–ны өдөр “Онцгой байдлын төлөвлөлт ба дүрвэгсдийн хамгаалалт” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар НҮБ–ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Дээд комиссарын албаны Ази, Номхон далайн бүсийн газар, Монгол Улс дахь НҮБ–ын Суурин зохицуулагчийн газар, мөн Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газрын төлөөлөгчид дүрвэгсдийн эрх зүйн байдал, дүрвэгсдийн хамгаалалт, олон улсын эрх зүйн зохицуулалт, үй олноор орж ирэх онцгой байдал, авах арга хэмжээний талаар илтгэл тавьж, бусад улсын туршлагатай танилцсан. Тус сургалтад Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Шадар сайдын Ажлын алба, Хууль зүй, дотоод хэргийн яам, Батлан хамгаалах яам, Эрүүл мэндийн яам, Онцгой байдлын ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Тагнуулын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Зэвсэгт хүчний жанжин штаб, Цагдаагийн ерөнхий газар, Стратеги судалгааны хүрээлэн, Монголын улаан загалмай нийгэмлэгийн төлөөлөгчид оролцсон.

Дүрвэгсдийн асуудлаар, тэр дундаа дүрвэгчийг буцаан өгөхгүй байх талаар хүлээсэн үүргээ тодорхойлохдоо хүн бүрт холбогдох хэргийг нэг бүрчлэн шатлан үнэлэх механизм тус улсад одоогоор байхгүй байна.

*10(e)–Оролцогч улс нь аливаа шатанд дипломат нотолгоо, баталгаа (diplomatic assurances or guarantees) гаргасан эсэх; хүлээн авсан эсхүл гарган өгсөн уг нотолгоо баталгаа, баталгааны агуулгад тавигдах наад захын шаардлага; эдгээр тохиолдлуудад хувьд хяналт хийхтэй холбоотойгоор авсан арга хэмжээ; шилжүүлэн өгөхөөс татгалзах зарчмыг тусгасан аливаа хоёр талт болон олон талт шилжүүлэн өгөх гэрээ, хэлэлцээрийг Оролцогч Улс байгуулсан эсэх;*

194. Тайлангийн хугацаанд буюу 2018 онд “Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын гэрээ”, 2019 онд “Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс хоорондын гэрээ”, мөн 2018 онд “Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс хоорондын гэрээ”, 2019 онд “Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс хоорондын гэрээ”–г тус тус байгуулсан.

195. “Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын гэрээ”–ний 4 дүгээр зүйлийн “d” хэсэгт “онцгой тохиолдолд хүсэлт хүлээн авагч тал хүсэлт гаргагч талын ашиг сонирхол, гэмт хэргийн ноцтой байдлыг харгалзан шилжүүлж

өгөхийг хүссэн гэмт этгээдийн хувийн нөхцөл байдлын улмаас гэмт этгээд шилжүүлэх нь хүмүүнлэг үзэлтэй нийцэхгүй гэж үзвэл шилжүүлэхээс татгалзаж болно” гэж заасан.

196. “Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс хоорондын гэрээ”-ний 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “е” дэд хэсэгт “хүсэлт гаргагч тал шилжүүлэхийг хүссэн этгээдийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хүний бие махбодыг доройтуулах болон хэрцгий хандах бодитой үндэслэлтэй хэмээн хүсэлт хүлээн авагч тал үзсэн бол гэмт этгээдийг шилжүүлэхээс татгалзана” гэж заасан.

197. Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс хоорондын гэрээ”-ний 5 дугаар зүйлд “Хүлээн авагч тал ялтан шилжүүлэн авсны дараа түүнд эрүү шүүлт тулгах, эсхүл хэрцгий болон хүнлэг бус шийтгэл ногдуулах магадлалтай гэх үндэслэл байвал ялтан шилжүүлэхээс татгалзаж болно” гэж заасан.

198. “Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс хоорондын гэрээ”-ний 5 дугаар зүйлд “аль нэг тал ... тухайн улсын үндэсний хууль тогтоомж дахь суурь зарчимд нийцэхгүй гэж үзвэл... ялтныг шилжүүлэхээс татгалзаж болно” гэж заасан.

## 5—9 дүгээр зүйлүүд

*11. Тайлангийн хугацаанд Конвенцийн 5 дугаар зүйлийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээнүүд, мөн уг зүйлийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалт бүхий хууль тогтоомжийн талаарх мэдээллийг өгнө үү.*

199. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.2 дугаар зүйлд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэмжээ хязгаарыг зааж өгсөн. Тодруулбал Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэр, түүнд хамаарах хилийн чанадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутаг, усан, агаарын орон зайд байгаа Монгол Улсын усан онгоц, агаарын хөлөгт гарсан гэмт хэрэгт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад нэгэн адил үйлчилнэ гэдгийг хуульчилсан.

200. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 42.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шүүх, прокурор, мөрдөгч нь гадаад улсын холбогдох байгууллага, албан тушаалтны мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай хүсэлтийг энэ хуульд заасан нийтлэг журмын дагуу биелүүлнэ.

201. Гадаад улсын нутаг дэвсгэрт мэдүүлэг авах, үзлэг, нэгжлэг, туршилт хийх, эд хөрөнгө хураан авах болон энэ хуульд заасан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах шаардлагатай бол уг асуудлыг эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай болон холбогдох бусад олон улсын гэрээний дагуу гүйцэтгэнэ.

*12. Тайлангийн хугацаанд бусад улсуудтай аливаа нэг шилжүүлэн өгөх тухай гэрээ, хэлэлцээрүүд байгуулсан эсэх талаар Хороонд мэдээлэл өгнө үү, эдгээр гэрээ, хэлэлцээрүүдэд Конвенцийн 4 дүгээр зүйлд заасан хэрэг, зөрчлүүд багтсан, агуулагдсан эсэх*



202. (Тайлангийн 194 дэх хэсгийг үзнэ үү.) “Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын гэрээ”-ний 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Энэхүү гэрээний зорилгоор шилжүүлбэл зохих гэмт хэрэгт талуудын хууль тогтоомжид зааснаар нэгээс доошгүй жилийн хугацаатай хорих ял шийтгүүлэх, эсхүл илүү хүнд ял оногдуулах гэмт хэргийг ойлгоно” гэж заасан.

203. “Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс хоорондын гэрээ”-ний 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Энэхүү гэрээний зорилгоор шилжүүлбэл зохих гэмт хэрэг гэдэгт талуудын хууль тогтоомжийн дагуу нэгээс доошгүй жилийн хугацаатай хорих ял шийтгүүлэх, эсхүл илүү хүнд ял оногдуулах гэмт хэргийг хэлнэ” гэж заасан.

*13. Оролцогч Улс нь тайлангийн хугацаанд бусад улс, олон улсын трибуналууд, олон улсын байгууллага, бусад нэгжүүдтэй шүүхийн шатанд харилцан туслалцаа үзүүлэх гэрээ, хэлэлцээр байгуулсан эсэх, эдгээр гэрээ хэлэлцээр нь бодит байдалд, практикт хэрэглэгдсэн эсэх, эрүүдэн шүүсэн, хүнлэг бусаар харьцсантай холбогдуулан яллах ажиллагаа явуулахтай холбогдуулан аливаа нотлох баримтыг дамжуулсан эсэх талаар тодруулж тайлбарлана уу. Жишээ гаргаж танилцуулна уу.*

204. Тайлант хугацаанд буюу 2018 онд “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын гэрээ”, 2018 онд “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн Засгийн газар хоорондын хэлэлцээр”, 2019 онд “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Макао хоорондын хэлэлцээр”-ийг тус тус байгуулсан.

205. Эрүүдэн шүүсэн, хүнлэг бусаар харьцсан гэмт хэрэгт яллах ажиллагаа явуулахтай холбогдуулан аливаа нотлох баримтыг олон улсын гэрээ, хоёр талт гэрээг үндэслэн бусад улсад дамжуулсан практик одоогоор байхгүй байна.

## **10 дугаар зүйл**

### **Сургалт**

*14. Хорооноос өмнө өгсөн ажиглалт дүгнэлт (37, 38 дахь параграф)-н дагуудараах мэдээллийг шинэчлэн гаргаж өгнө үү.*

*14(a)-Цагдаа, бусад хууль сахиулах албан хаагчид, шүүгч, прокурор болон хуульчид Конвенцийн зүйл, заалтуудын талаар тэр дундаа хүний наймаа болон эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэх, эрүү шүүлт тулгахыг туйлаас хориглох тухай сургалтад хангалттай хамрагддаг эсэх;*

206. Монголын хуульчдын холбооноос хуульчдын сургалтыг нэгдсэн байдлаар зохион байгуулдаг. Хүний эрхийн чиглэлийн сургалт нь мэргэжлийн суурь сургалтад хамаардаг. Мэргэжлийн суурь сургалтын хөтөлбөрийг хоёр жил тутам төлөвлөж боловсруулдаг.

207. Тус холбооноос “Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах, багц цаг тооцох журам”-ыг баталсан. Тус журмын 3.1 дүгээр зүйлийн 3–т хууль зүйн мэргэшлийн чиглэлээр сургалт явуулдаг байгууллагууд сургалтын хөтөлбөрөө холбооны Сургалтын хороогоор магадлан итгэмжлүүлж, зөвшөөрлийн үндсэн дээр хуульчдад зориулсан сургалтыг зохион байгуулж болно. Үүний хүрээнд хүний эрхийн чиглэлийн тэр дундаа конвенцийн талаарх сургалтад бусад хуульчдыг хамруулах нэгдсэн тогтолцоо үр дүнтэй ажиллах боломж бий болсон. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд заагдсан “Эрүү шүүлт тулгах” гэмт хэргийн субъект болох Төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлж байгаа албан хаагчдыг тухайн төрлийн гэмт хэргийг үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтын хөтөлбөр боловсруулаад байна.

208. Хүний эрхийн үндэсний Комисс 2016 онд Монголын хуульчдын холбооны Хуульчдын үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хороогоор нэр бүхий 8 сэдвийг магадлан итгэмжлүүлж, хуульчдад багц цагийн сургалт зохион явуулж эхэлсэн бөгөөд эдгээрийн нэг нь “Хүний эрхийн олон улсын гэрээг шүүхийн практикт хэрэглэх нь” сэдэвт модуль юм. Энэхүү модульд тус конвенцийн талаарх дэд сэдвийг багтаан сургалтын үйл ажиллагааг зохион явуулж байгаа бөгөөд цаашид уг Конвенцоор дагнасан сургалтын модулийг боловсруулах мөн соён гэгээрүүлэх ажлын талаар НҮБ болон бусад байгууллагатай хамтран ажиллах боломжийг эрэлхийлж байна. Тухайлбал Хүний эрхийн үндэсний комиссоос ажилтан урьж Орхон аймгийн цагдаагийн газраас тус байгууллагын эрх бүхий албан хаагчид болон Прокурорын газрын хяналтын прокуроруудыг оролцуулан “Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаарх” сургалтыг 2020 оны 07 дугаар сарын 01–ны өдөр зохион байгуулсан. Уг сургалтад нийт 64 ажилтан алба хаагч хамрагдсан.

209. Хууль сахиулах байгууллагуудын хувьд конвенцийн зүйл, заалтуудын талаар тэр дундаа хүний наймаа болон эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэх, эрүү шүүлт тулгахыг хориглох тухай сургалтыг салбар, салбарын байгууллагуудын хүрээнд тогтмол зохион байгуулж байна. Тухайлбал: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 20–ны өдрийн А/94 дүгээр “Хөтөлбөр батлах тухай” тушаалын дагуу хотын бүсийн хорих анги, байгууллагын 3–5 жил ажиллаж байгаа харуул хамгаалалтын ажилтнуудын мэргэшүүлэх давтан сургалтыг 2019 оны 12 дугаар сарын 09–нөөс 12 дугаар сарын 20–ны өдрийн хооронд 409 дүгээр хаалттай хорих анги, Дотоод хэргийн их сургуулийн байршилд зохион байгуулж, “Эрүү шүүлтээс ангид байх” сэдэвт сургалтад нийт 65 алба хаагчийг хамруулсан.

210. Хорих анги байгууллагын нийт алба хаагчдын жил бүрийн сургалтын төлөвлөгөөнд “Хүний Эрх” сэдэвт бие даасан бүлэг сургалтыг нэмэлтээр тусгаж, эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах үйлдлийг ялгах талаар мэдээ, мэдээллээр тогтмол хангаж хэвшсэн бөгөөд 2020 оны 09 дүгээр сарын байдлаар нийт 51 хорих анги, байгууллагын 2255 алба хаагч сургалтад хамрагдсан.

211. Нийслэлийн дүүргүүд дэх цагдаагийн хэлтэс тус бүрээс 1 албан хаагчийг Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэл хариуцсан хэлтэст 2018 оны 1 дүгээр сарын 15–наас 1 сарын хугацаатайгаар ажиллуулан туршлага судлуулсан ба 2018 оны 03 дугаар сарын 15–ны өдөр Цагдаагийн ерөнхий газрын Сургалт, дадлагын төвд зохион байгуулагдсан

“Гүйцэтгэх ажлын эрх олгох, мэргэшүүлэх давтан сургалт”–д хамрагдсан төв орон нутгийн 80 мөрдөгчдийг “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй гүйцэтгэх ажлаар тэмцэх нь” сэдвээр 7 цагийн сургалтад хамрууллаа. Цагдаагийн байгууллага, Хүний эрхийн үндэсний комиссын хооронд байгуулсан “Санамж бичиг”–ийн хүрээнд Цагдаагийн байгууллагын хэмжээнд “Хүний эрхийн сургагч багш бэлтгэх” сургалтыг 2017 оны 10 дугаар сарын 11–ний өдрөөс 13–ны өдрүүдэд, 2018 оны 4 дүгээр сарын 25–ны өдрөөс 27–ны өдрүүдэд тус тус зохион байгуулж төв орон нутгийн цагдаагийн анги байгууллагын 49 алба хаагчийг хамруулсан.

212. Нийслэлийн Прокурорын газраас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран зохион байгуулсан зөвлөгөөн болон Нийслэл, дүүргийн прокурорын газруудын хамтарсан сахилга, хариуцлагын зөвлөгөөнд “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгийн, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц” болон “Монгол Улсын нэгдэн орсон бусад олон улсын гэрээ, конвенцийг хэрэгжүүлэх, эрүү шүүлт тулгах, эрүүдэн шүүхээс ангид байх эрх” сэдвээр тус тус сургалт зохион байгуулав.

213. 2020 оны 02 дугаар сарын 20–ны өдрөөс 21–ний өдрүүдэд “Хүний эрхийн сургагч багш бэлтгэх” давтан сургалтыг цагдаагийн байгууллагын хэмжээнд зохион байгуулж “Хүний эрхийн сургагч багш”–аар бэлтгэгдсэн төв, орон нутгийн цагдаагийн анги байгууллагын 35 алба хаагчийг хамрууллаа. Сургалтад “Хүний эрхийн үндсэн ойлголт, зарчим, хүний эрхэд суурилсан хандлага”, “Олон улсын хүний эрхийн гэрээ, механизм”, “Жендерт суурилсан хүчирхийлэл ба гэр бүлийн хүчирхийлэл”, “Хүүхдийн эрх”, “Амьд явах, халдашгүй чөлөөтэй байх эрх”, “Эрүү шүүлтээс ангид байх эрх чөлөө” сэдвүүдээр Хүний эрхийн үндэсний комиссын сургагч багш нар багаар болон кейс дээр ажиллах, хэлэлцүүлэг зохион байгуулах хэлбэрээр сургалтын интерактив аргуудыг ашиглан явуулсан.

214. Хүний эрхийн сургагч багш бэлтгэх сургалтад хамрагдсан төв, орон нутгийн цагдаагийн байгууллагын алба хаагчдыг хүний эрхийн талаар багаар болон ганцаарчилсан байдлаар сургалтын конспект бэлтгэх үүрэг хүлээлгэсэн. Хүний эрхийн сургагч багшаар бэлтгэсэн алба хаагчдад цаашид анги байгууллагууддаа хүний эрхийг хөхүүлэн дэмжих чиглэлээр сургалт зохион байгуулж, ажиллах юм. Цаашид бие даан сургалт удирдан явуулах чиглэлээр Хүний эрхийн үндэсний комиссын алба хаагч нар мэргэжлийн зөвлөгөө өгч хамтран ажиллаж байна. Сургалтын явцад гарч болох тулгамдсан асуудлууд, цаашид анхаарч ажиллах чиглэлд байнгын хамтын ажиллагаатай ажиллахаар болсон.

215. Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын “Хүн худалдаалахтай тэмцэхэд Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон Монгол Улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд 2019 оны 10 дугаар сарын 18–ны өдөр БНХАУ–ын Бээжин хотноо зохион байгуулж байгаа Монгол Улс болон БНХАУ–ын Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудын удирдах ажилтнуудын уулзалтад Хууль зүй, дотоод хэргийн яам болон харьяа байгууллага, агентлагаас 5 албан тушаалтан, 12 дугаар сарын 11–12–ны өдрүүдэд Бээжин хотноо зохион байгуулсан хоёр улсын цагдаагийн байгууллагын хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ажилладаг алба хаагчдын хамтарсан сургалтад Цагдаагийн байгууллагын 8 алба хаагч, Дотоод хэргийн их сургуулийн 2 багш тус тус оролцсон.

Эрүү шүүлт, зүй бус харьцаанаас ангид байх, түүнээс урьдчилан сэргийлэх сэдвээр хууль сахиулах байгууллагууд, шүүх, прокурорын байгууллага өөрсдийн чиг үүрэгт хамаарах хүрээнд дотооддоо сургалтууд явуулах зорилгоор тухайн жилдээ сургалт төлөвлөдөг. Сургалтын агуулгыг хүний эрх гэсэн ерөнхий сэдвийн хүрээнд явуулах боловч тус конвенцийн зүйл, заалтуудын талаар тусгайлсан сургалт дутагдалтай хэвээр байна. Мөн эрүү шүүлт тулгах гэмт хэргийг илрүүлэхэд эмч, эмнэлгийн ажилтны мэдлэг, хандлага хангалтгүй байна. Энэ чиглэлийн сургалтын хөтөлбөр боловсруулах, тусгайлан конвенцийн зүйл, заалтуудын талаар сургалт зохион байгуулахад Хороотой хамтарч ажиллах шаардлага байна.

*14(b)–Эрх чөлөөг нь хязгаарласан хүмүүстэй ажилладаг эмнэлгийн ажилтан, эрүүл мэндийн мэргэжилтнүүд, бусад төрийн албан хаагчдад зориулсан сургалтын нэг салшгүй хэсэг болгон эрүүдэн шүүсэн, бусад байдлаар харгис, хүнлэг бус, нэр төр доромжлон харьцсан, зүй бусаар шийтгэсэн талаарх баримтууд (Истанбулын Протокол) болон үр дүнтэй мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай гарын авлага дахь агуулгаар сургалт явуулсан эсэх;*

216. Эрүүл мэндийн сайдын 2013 оны 12 дугаар сарын 09–ний өдрийн 462 дугаар тушаалаар баталсан “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод сэтгэцийн нөхөн сэргээх тусламж үйлчилгээг үзүүлэх тухай” журмын талаар мэдээлэл өгөх сургалтыг 2018 оны 03 дугаар сарын 14–ний өдөр, 05 дугаар сарын 30–ны өдрүүдэд тус тус зохион байгуулж нийт 50 эмч, нийгмийн ажилтанг хамруулсан. Мөн уг журмыг “Сэтгэцийн эмчийн баримталвал зохих эрх зүйн баримт бичиг” эмхтгэлд оруулан 250 ширхэг хэвлүүлж орон нутгийн болон Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн эмч нарт хүргүүлсэн.

217. Эрүүдэн шүүх, зүй бус харьцах асуудлыг мөрдөн шалгах, баримтжуулан тогтоохтой холбоотой ажил, үүрэг хүлээдэг шүүгч, прокурор, эрүүл мэндийн ажилтнууд болон энэ салбарт хамаарах ажил хийдэг бусад албан хаагчдыг Истанбулын протокол, эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах үйлдлийг зогсоох, тэдгээр үйлдлүүдийг ялгах, ангилах, тусгайлсан эрүүл мэндийн үзлэг хийх зэрэг олон улсын стандартын тухай сургалтад хамруулж байна.

218. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2017 оны 10 дугаар сарын 17–ны өдрийн А/214 тоот тушаалаар баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу 2017 оны 10 дугаар сарын 19, 20–ны өдрүүдэд 401 дүгээр хаалттай хорих анги Нэгдсэн эмнэлгийн байранд эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд Истанбулын Протоколын талаар сургалт хийсэн.

219. Хорих анги, байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэхэд гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг ухамсарлуулах үүднээс Истанбулын протоколыг судлуулах, нэг мөр хэрэгжүүлэх зорилгоор эмч, эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн сургалтыг 2018 оны 11 дүгээр сарын 28, 29–ний өдрүүдэд мөн зохион байгуулсан.

Истанбулын протоколын зүйл, заалтын талаарх сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, протоколын дагуу үүрэг хүлээж буй алба хаагчдын протоколын талаарх ойлголт, мэргэжлийн ур чадварыг сургалтаар дамжуулан дээшлүүлэх талаар Хороотой хамтран ажиллах хэрэгцээ, шаардлага байна.

*14(с)–Эрүүдэн шүүсэн, зүй бус харьцсан гэмт хэргийн тоог бууруулах үүднээс сургалтын хөтөлбөрийн үр ашигтай байдлыг үнэлэх тодорхой арга зүйг Оролцогч Улс боловсруулсан эсэх; ийм хөтөлбөр боловсруулсан бол арга зүйн талаар мэдээлэл өгнө үү.*

220. Хүний эрхийн чиглэлийн сургалтын явцын үнэлгээ хийх, сургалтын хөтөлбөрт нэгдсэн үнэлгээ хийх арга зүйг тусгайлан боловсруулаагүй байна.

## **11 дүгээр зүйл**

*15. Конвенцийн 11 дүгээр зүйлд нийцүүлэн газар дээр нь нягтлан шалгахтай холбоотой ажиллагааны процедурыг тайлбарлана уу, байцаалт авахтай холбоотой журмууд, заавар, удирдамж, хэрэглэж буй арга барил болон бодит практикийн талаарх мэдээлэл, мөн тайлангийн хугацаанд шинээр хэрэглэж байгаа, баривчлан түр саатуулахын тулд авах ёстой арга хэмжээний талаар, уг процессыг шалгах, хянадаг эсэх, хяналт шалгалтыг хир давтамжтай хугацаанд хийдэг эсэх, тогтмол хийгддэг эсэх талаар тайлбарлана уу.*

221. Баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх үйл ажиллагааг прокурорын байгууллагаас улирал тутамд нэгээс доошгүй удаа, мөн гэнэтийн байдлаар шалгалт тогтмол явуулж байна.

222. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 25.6 дугаар зүйлд мэдүүлгийг газар дээр нь шалгах аргаар зохицуулсан. Илэрсэн нөхцөл байдлыг шалгах, явсан замыг тогтоох, зааж өгсөн газрыг шалгах, урьд өгсөн мэдүүлгийн үнэн зөвийг харьцуулан тогтоох зорилгоор яллагдагчийн зөвшөөрснөөр, эсхүл мөрдөгч өөрийн санаачилгаар мэдүүлгийг газар дээр нь шалгаж болно. Түүнчлэн ажиллагааны үед мэдүүлгээ шалгуулж байгаа хүн хэрэгт ач холбогдол бүхий зарим тухайлсан зүйл, баримт бичиг, ул мөрийг заах, тодорхой үйлдлийг хийж үзүүлэх, шинжлэн судалж байгаа хэргийн нөхцөл байдалд, үйл явдал болсон газрын байдал яаж өөрчлөгдсөн тухай зааж, урьд өгсөн мэдүүлгээ газар дээр нь тодорхой болгон дэлгэрэнгүй тайлбарлана.

223. Мэдүүлэг өгсөн хүн чөлөөтэй ярьж, үйлдлээ үзүүлсний дараа түүнд асуулт тавьж болно. Нэг дор, нэг газарт, хэд хэдэн хүний мэдүүлгийг газар дээр нь нэгэн зэрэг шалгахыг хориглоно. Мэдүүлгийг газар дээр нь шалгаж байхад хөндлөнгөөс оролцох, хөтлөх, сануулах асуулт тавихыг хориглоно гэж заасан бөгөөд яллагдагчийн өгсөн мэдүүлгийг нотлох зорилгоор уг мөрдөн шалгах ажиллагааг явуулдаг.

224. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 25.1 дүгээр зүйлд мэдүүлэг авах талаар зохицуулсан. Мөрдөгч мэдүүлгийг мэдүүлэг авах шаардлага хангасан өрөөнд авна. Шаардлагатай бол мэдүүлгийг тухайн хүний байгаа газарт очиж авч болно. Хуульд заасан энэ зохицуулалтыг хэрэгжүүлэхэд мөрдөгчдөд тодорхой бэрхшээл учирч байдаг. Ихэнх тохиолдолд мэдүүлэг өгч буй хүмүүс мөрдөгч нарын үйл ажиллагааг дэмждэг ч, нөгөө талаас тэднийг гүтгэх асуудал түгээмэл байна. Үүнээс зайлсхийхийн тулд мөрдөгч болгонд дуу болон дуу–дүрсний бичлэг хийдэг төхөөрөмжөөр хангах, үүнийг шийдвэрлэх

боломжийг судлах шаардлага үүсч байна.

225. Мөрдөгч мэдүүлэг өгөх хүнийг болон шинжээчийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 12.1, 12.2 дугаар зүйлд заасны дагуу дуудан ирүүлэх, эсхүл энэ хуулийн 12.3 дугаар зүйлд заасны дагуу албадан ирүүлж болно.

226. Мэдүүлэг авах хүмүүсийг тус тусад нь байлгаж мэдүүлэг авах ба мөрдөгч нэг хэрэгт мэдүүлэг авах хүмүүсийг өөр хоорондоо харилцахгүй байх арга хэмжээ авна.

227. Мөрдөгч мэдүүлгийн эхэнд тухайн хүний хувийн бичиг баримтыг шалгаж, түүнд ямар зорилгоор мэдүүлэг авахаар хэзээ, хэн гэдэг прокурорын шийдвэрээр дуудан ирүүлсэн, түүнчлэн энэ хуульд заасан эрх, үүргийг нь танилцуулсан тухай тэмдэглэлд тусгана.

228. Мөрдөгч мэдүүлэг өгөх гэж байгаа хүнд өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэйг нь тайлбарлах ба санаатай худал мэдүүлэг өгвөл Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай сануулна. Хойшлуулушгүй, эсхүл тухайн хүн хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд шөнийн цагаар мэдүүлэг авахыг хориглох талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 25.1 дүгээр зүйлийн 12 дахь хэсэгт заасан.

229. Тухайн хүн мэдүүлэг өгөхдөө эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар мэдэх зүйлээ ярина. Ярьж дууссаны дараа ярьсан зүйлтэй нь холбогдуулан түүнд тодруулах асуулт тавьж болно.

230. Мэдүүлэг өгөх хүн баримт бичиг, бичлэг ашиглаж болно. Мэдүүлэг өгөхөд ашигласан зүйл, тухайн хүний үйлдсэн зураглал, хүснэгт, зургийг бүрэн эхээр нь, эсхүл хуулбарыг нь тэмдэглэлд хавсаргаж болох ба энэ тухай тэмдэглэлд тусгана.

231. Мэдүүлэг авсны дараа дахин мэдүүлэг авах үед өмнөх мэдүүлэгтэй нь холбогдуулан мөрдөгч эд мөрийн баримт, баримт бичиг, бусад нотлох баримтыг мэдүүлэг өгч байгаа хүнд үзүүлж, бусад мэдүүлгийн тэмдэглэлийг танилцуулж болох ба энэ талаар тэмдэглэлд тусгана.

232. Мэдүүлэг авахад орчуулагч, хэлмэрч оролцуулах бол түүнд эрх, үүргийг тайлбарлан, санаатайгаар худал орчуулах, эсхүл хэлмэрчилбэл хүлээлгэх хариуцлагыг урьдчилан сануулж, тэмдэглэлд гарын үсэг зуруулна.

233. Хэл яриа, сонсголын бэрхшээлтэй хүнээс мэдүүлэг авахад хэлмэрчийг оролцуулах боломжгүй бол түүний зөвшөөрснөөр бичгээр асуулт тавьж, мэдүүлэг авч болно. Мэдүүлэг авах үед хөтөлж, эсхүл тулгаж асуулт тавихыг хориглоно.

234. Мэдүүлэг авах ажиллагааг тэмдэглэл, дууны, эсхүл дүрсний, эсхүл дуу–дүрсний бичлэгээр бэхжүүлж болно. Дууны, эсхүл дүрсний, эсхүл дуу–дүрсний бичлэгээр бэхжүүлэх бол мэдүүлэг өгч байгаа хүнд урьдчилан мэдэгдэнэ.

235. Мэдүүлэг өгч байгаа хүн хүсвэл түүнд мэдүүлгээ өөрөө бичих бололцоо олгож, энэ тухай тэмдэглэлд тусгана. Мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлагыг Улсын ерөнхий прокурор батална. (Тайлангийн 133, 134 дэх хэсгийг үзнэ үү.)

## Хорих байрны нөхцөл

*16.Хорооноос өмнө өгсөн ажиглалт дүгнэлт (19, 20 дахь параграф)–н дагуудараах мэдээллийг гаргаж өгнө үү.*

*16 (а)–Хүний эрх чөлөөг хязгаарлаж буй бүх байруудад тэр дундаа Дэнжийн Мянга дахь баривчлах байрны эрүүл ахуйн байдал болон материаллаг нөхцөл сайжирсан эсэх, хэт олон хүн байрлуулахыг өөрчилж, хүний тоог багасгах, бууруулах талаар Оролцогч Улс тодорхой арга хэмжээ авсан эсэх;*

236. Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу Хууль зүйн сайдын үүрэг гүйцэтгэгчийн 2014 оны 09 дүгээр сарын 29–ний өдрийн А/162 дугаар тушаалаар Нийслэлийн цагдаагийн газрын харьяа Дэнжийн Мянга дахь Албадан саатуулах, баривчлах төвийн зарим орон тоо, төсөв, эргэлтийн бус хөрөнгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяанд шилжүүлсэн. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяанд байх Дарь–Эх дэх байранд нүүлгэн шилжүүлж баривчлах төвийг байгуулсан. Тус баривчлах төв 28 албан хаагчийн орон тоотой үйл ажиллагаа явуулж байна. (Тайлангийн 173, 174 дэх хэсгийг үзнэ үү.)

237. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд зааснаар 1 хүнд ноогдох талбайн хэмжээ 2.5 метр.кв байхаас шинээр ашиглалтад орсон хорих өрөөний талбайн хэмжээ дунджаар 3–3.5 метр.кв болж нэмэгдэн, байгалийн гэрэл чөлөөтэй тусах, агаарын солилцоо бүрэн хийгдэх нөхцөлийг хангаад байна.

238. Саатуулах байранд Зөрчлийн тухай хуулиар 24–48 хүртэл цагийн хугацаатай саатуулагдсан этгээдүүдийг байрлуулдаг бөгөөд энэ ажиллагаанд прокурорын байгууллагаас хяналт тавьдаг. Нөхцөл байдалтай 14 хоног тутам танилцаж, улирал бүр шалгаж, хяналт тавин ажилладаг. Зарим тохиолдолд гэнэтийн байдлаар шалгаж танилцах ажиллагааг явуулж илэрсэн зөрчлийг арилгуулж ажиллаж байгаа нь үр дүнгээ өгч байна.

239. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/185 тоот тушаалаар батлагдсан “Саатуулах байрны дэглэм журам”–ын 2.13–т зааснаар саатуулах байрны ахуй нөхцөлийн байдалд Мэргэжлийн хяналтын байгууллагаар дүгнэлт гаргуулсан байна” гэж заасны дагуу жилд хоёроос доошгүй удаа дүгнэлт гаргуулж байна.

240. Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангийн хуяглан хүргэлтийн хэлтсийн байршилд олон хоригдол шийдвэр хүлээн төвлөрөх байдал арилсан. Хорих өрөө бүрийг ортой болгон цагаан хэрэглэлийг 7 хоногт 1 удаа сольж байна.

241. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/185 дугаар тушаалаар батлагдсан “Саатуулах байрны дэглэм, журам”–д “саатуулах байр нь халуун, хүйтэн ус, бохирын систем, байгалийн гэрэлтүүлэг, агааржуулалтын систем зэрэг ажиллагсад, саатуулагдсан хүний эрүүл мэнд, аюулгүй байдлын шаардлагыг хангахуйц орчин, нөхцлийг бүрдүүлсэн байна”. Мөн журмын 2.4–т “саатуулах байрны өрөө нь саатуулагдсан нэг хүнд 2 м<sup>2</sup>–аас доошгүй талбай ногдох нөхцөлийг бүрдүүлсэн байна” гэж зааж саатуулах байрны стандартыг бүрдүүлж өгснөөр эрүүл ахуйн болон аюулгүй байдлын нөхцөл сайжирсан байна.

*16(b)–Тайлангийн хугацаанд хорих байруудад эрүүл мэндийн халамж үйлчилгээ, амьдрах нөхцөлийг сайжруулахын тулд хийгдэж буй шалгалтын хүрээнд зохих хэмжээний нөөцийг хуваарилж байсан эсэх, хорих байрууд дахь эрүүл мэндийн халамж үйлчилгээ болон эмнэлгийн үйлчилгээг Эрүүл мэндийн яаманд хариуцуулахаар шилжүүлсэн эсэх;*

242. (Тайлангийн 121 дэх хэсгийг үзнэ үү.) Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 203 дугаар зүйлийн 203.5 дахь хэсэгт заасны дагуу хорих эмнэлгийг мэргэжил, арга зүйн удирдлага, боловсон хүчнээр хангах үүргийг Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хүлээнэ.

243. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт заасны дагуу хоригдсон этгээдийг хорих шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтны эсхүл түүний удирдах албан тушаалтны бичгээр олгосон зөвшөөрлөөр төрөл садан болон бусад хүмүүстэй уулзалтыг зохион байгуулж байгаа ба уулзалтын өрөө тасалгааг хоригдогсдод хүртээмжтэйгээр бий болгосон.

244. 2020 оны 09 дүгээр сарын байдлаар улсын хэмжээнд хаалттай 7, нээлттэй 7, нээлттэй, хаалттай дэглэмтэй 3 хорих анги, сургалт–хүмүүжлийн тусгай байгууллага 1, эмнэлэг 2, эмэгтэйчүүдийн хорих анги 1, нийт 21 хорих анги, Нийслэлд Цагдан хорих төв 1, орон нутагт 26 цагдан хорих байртайгаар үйл ажиллагаа явуулж байна.

245. Хорих ангийн дотоод журмын 4.2 дахь хэсэгт “Халуун усны газарт шүршүүрийг байрлуулж, батлагдсан хуваарийн дагуу 14 хоног тутам хоригдлыг усанд оруулж, бүртгэл хөтлөх ба хөдөлмөрийн нөхцөлөөс хамааран тухай бүр усанд оруулж болно” гэж заасны дагуу бие засах газар, халуун усны хэсгийг бохирын нэгдсэн шугам сүлжээнд холбох ажлыг үе шаттайгаар авч хэрэгжүүлсэн. Хаалтыг хоригдлын биеийг бүрэн халхлахаар зохион байгуулж, хоригдлын удаан хугацааны эргэлтийн байранд бие засах газар, халуун усыг цогцоор нь шийдсэн.

246. Эрүүл мэндийн яамны 2020 оны 02 дугаар сарын 13–ны өдрийн 1–4/725 дугаар зөвлөмжийн дагуу алба хаагч, хоригдол, хоригдогчдод амьдралын бүс, хорих өрөө болон эмнэлгийн орчны цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжилтийг хэрхэн хийх талаар сургалтын видео бэлтгэн хорих анги, байгууллагуудад хүргүүлж, холбогдох арга хэмжээг зохион байгуулан цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг тогтмол хийлгэж, ариутгалын бодисыг автомаксаар агаарт дуслан тоосонцор үүсгэх хэлбэрээр халдваргүйжүүлэх ажлыг өдөрт 2 удаа хийж хэвшүүлсэн.

*16(c)– 2016 онд барилгын ажил бүрэн дуусахаар хугацаа товлогдсон байсан дөрвөн хорих төвийн нэр, байршил;*

247. Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн барилга нь 2016 оны 11 дүгээр сарын 09–нд ашиглалтад орсон. 2 давхар бүхий 740 м<sup>2</sup> талбайтай, 7 өрөөтэй нийт 29 хоригдогч хүлээн авах багтаамжтай.

248. Завхан аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын барилга нь 2016 оны 11



дүгээр сарын 10–нд ашиглалтад орсон. Нэг цонхны үйлчилгээ, цагдан хорих байр бүхий 1440м<sup>2</sup> талбайтай байгууламж, 23 өрөөтэй нийт 76 хоригдогч хүлээн авах багтаамжтай.

249. Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын барилга нь 2016 оны 10 дугаар сарын 14–нд ашиглалтад орсон. Нэг цонхны үйлчилгээ, цагдан хорих байр бүхий 1440м<sup>2</sup> талбайтай байгууламж, 13 өрөөтэй нийт 66 хоригдогч хүлээн авах багтаамжтай.

250. Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын барилга нь 2016 оны 11 дүгээр сарын 26–нд ашиглалтад орсон. Нэг цонхны үйлчилгээ, цагдан хорих байр бүхий 1440м<sup>2</sup> талбайтай байгууламж, 18 өрөөтэй нийт 58 хоригдогч хүлээн авах багтаамжтай.

*16(d)–Сэтгэцийн эмгэгтэй болон нийгмийн халамжийн байранд байх шаардлагатай хүмүүст зориулсан институц зэргийг хамруулан хүний эрх чөлөөг хязгаарлан байлгаж байдаг бүхий л газруудад хараат бусаар, тогтмол хяналт шалгалт хийхийг бэхжүүлэх талаар авсан тодорхой арга хэмжээ;*

251. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Шүүхийн сэтгэц, эмгэг судлалын клиникт эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх шүүхийн шийдвэрээр 35 хүн албадан эмчлүүлж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас харуул хамгаалалтыг зохион байгуулан ажиллаж, тогтмол хяналт тавин ажиллаж байна.

252. Хүний эрх чөлөөг хязгаарлан байлгаж байдаг бүхий л газруудад тогтмол хяналт шалгалтыг прокурорын байгууллага мөн хийж байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон Улсын ерөнхий прокурорын тушаалаар батлагдсан хяналтын ажлын зааврын дагуу прокуророос хүний эрх чөлөөг хязгаарлан байлгадаг бүхий л газруудын үйл ажиллагаатай долоо хоногт эсхүл арван дөрөв хоног тутам тогтмол танилцан сард нэг удаа гэнэтийн байдлаар шалгалт хийж хяналтыг хэрэгжүүлдэг. Түүнчлэн бие даасан, хараат бусаар шалгалт хийх эрх Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисст хуулиар олгогдсон.

253. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1–т хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн талаарх гомдол, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар, эсхүл иргэн, байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдийн хүсэлтээр шалгалт хийх Комиссын гишүүний бүрэн эрхийг заасан. Тайлангийн хугацаанд тухайлбал хүүхдийн эрхийн форумас Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын харьяа Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байранд байрлаж буй хүүхдийн эрх зөрчигдөж байгаа талаар гомдол, мэдээллийг Хүний эрхийн үндэсний комисст ирүүлсний дагуу түр хамгаалах байрны үйл ажиллагаа болон байрлаж буй хүүхдүүдийн эрхийн хэрэгжилтэд Хүний эрхийн үндэсний комиссын зүгээс хяналт шалгалт хийсэн.

254. Хүний эрхийн үндэсний комиссын дэргэд эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх асуудал хариуусан гишүүн томилогдсоноор хүний эрх чөлөөг хязгаарлан байлгадаг бүх газруудад хараат бусаар, тогтмол хяналт шалгалт хийх механизм бэхжинэ.

*16(e)–Үндэсний урьдчилан сэргийлэх механизмын хүрээнд Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс нь хүний эрх чөлөөг хязгаарлан байлгадаг бүхий л газруудад тэр дундаа сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийг байлгадаг болон нийгмийн халамж үзүүлдэг байруудад тогтмол очдог байсан эсэх;*

255. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх буюу аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлах зорилгоор тогтмол хяналт шинжилгээ хийх чиг үүрэг хэрэгжүүлнэ. Энэ хуульд заасан “бүх газарт” гэдэгт хорих байгууллага, цагдан хорих анги, түр болон албадан саатуулах газар, сэтгэцийн эрүүл мэндийн төв, хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон ахмадын асрамжийн газар, сургуулийн дотуур байр, албадан эмчилгээний байр, дүрвэгсдийн байр, цэргийн сахилгын байр, хилийн шалган нэвтрүүлэх боомт дахь түр саатуулах болон хамгаалах байрыг ойлгоно.

256. (Тайлангийн 149, 251 дэх хэсгийг үзнэ үү.) Шүүх сэтгэц, эмгэг судлалын үндэсний төвийн Сэтгэц эмгэг судлалын клиникийн тусгай болон ердийн тасагт прокурор хяналт тавьж байна. Тус төвд жилд дунджаар 62 хүн өвчний учир шүүхийн тогтоолоор ялаас чөлөөлөгдөн албадан эмчилгээ хийгддэг байна.

257. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд нарын хамтарсан 2017 оны 09 дүгээр сарын 21–ний өдрийн А–240/А/369 дугаартай тушаалаар баталсан “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”–ын дагуу явагдаж байгаа эсэх, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 190 дүгээр зүйлийн 190.5 дахь хэсэгт заасан үүргийг хэрэгжүүлж байгаа эсэх, албадан эмчлүүлж байгаа этгээдийн ахуй нөхцөл, хоол ундны хангалтыг ердийн өвчтөний нэгэн адил бүрдүүлсэн эсэх, байрны харуул хамгаалалт тогтоосон журмын дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллана.

258. Эмнэлгийн захиргааны зөвшөөрлөөр албадан эмчлүүлж байгаа этгээдийн ар гэрээс сард 1 удаа түр эргэлт оруулж байгаа байдал, өдөр бүр салхилуулж байгаа эсэхтэй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас бүртгэлээр танилцан ажиллаж байна.

259. Прокурорын тухай хуулийн 5 дугаар зүйлд зааснаар прокурор хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, түүнийг зөрчигдөхөөс сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх арга хэмжээ авна. Тус чиг үүргийнхээ хүрээнд согтуурах, мансуурах донтой этгээдийг албадан эмчлэх газарт эмчлүүлж буй хүмүүсийн эрх зөрчигдөж буй эсэхэд хяналт тавьдаг.

*16(f)–Тайлангийн хугацаанд бие даасан, хараат бус нэмэлт механизм бий болгосон эсэх, тухайн механизмд цагдан хоригдож байгаа хоригдлуудаас хоригдож байгаа нөхцөлийн талаар гомдол хүлээж авах, гомдлын мөрөөр арга хэмжээ авах эрх хэмжээ бий эсэх;*

260. Тайлангийн хугацаанд бие даасан, хараат бус нэмэлт механизм бий болгосон. (Тайлангийн 8, 9, 140, 148 дахь хэсгийг үзнэ үү.) Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 22 дугаар зүйлдхоригдсон этгээд өргөдөл, гомдол гаргах талаар хуульчилсан. Хоригдсон этгээд нь төрийн болон нутгийн захиргаа, бусад байгууллага, албан тушаалтанд явуулах өргөдөл, санал, гомдлоо хорих байрны захиргаагаар дамжуулан илгээнэ.

261. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 235 дугаар зүйлийн 235.6 дахь хэсэгт зааснаар хорих анги, алба хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хаягласан захидлын агуулга, тоо хэмжээнд хяналт тавихгүй бөгөөд хорих ангийн захиргаа уг захидлыг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор илгээнэ.

262. Шүүх, прокурор болон хорих байрны үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий төрийн бусад байгууллагад явуулах өргөдөл, санал, гомдлыг хорих байрны захиргаа хянаж шалгаж болохгүй бөгөөд өргөдөл, санал, гомдлыг хүлээн авсан өдрийн дараагийн өдрөөс хэтрүүлэхгүйгээр битүүмжилсэн дугтуйгаар зохих байгууллагад илгээнэ. Бусад төрийн байгууллага, албан тушаалтанд хаягласан өргөдөл, санал гомдлыг хорих байрны захиргаа хянаж, хүлээн авсан өдрөөс хойш гурав хоногийн дотор илгээнэ. Мөрдөгч, прокурорын үйл ажиллагаатай холбогдолтой гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш гурав хоногийн дотор холбогдох байгууллагад нь илгээнэ.

263. Өөрийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалуулахаар өргөдөл, санал, гомдол гаргасан хоригдож буй этгээдийг хавчин хяхах, мөрдөн мөшгөхийг хориглоно. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.7 дахь хэсэгт заасны дагуу ийнхүү хавчин хяхсан, мөрдөн мөшгөсөн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж заасан.

264. Улсын Ерөнхий прокурорын газраас хорих ял эдлүүлэх, сэжигтнийг баривчлах, яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан ажиллагааны хууль зүйн үндэслэл, эдгээр ажиллагааны явцад хүний эрхийг зөрчсөн, эрүүдэн шүүсэн аливаа хэрэг, зөрчил гарсан эсэх, илэрсэн зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах, давтан гаргуулахгүй байх шалгалтыг тогтмол хийдэг. Тухайлбал: 2019 оны шалгалтаар мөрдөгч нар хэрэг шалгах явцад эрүүдэн шүүсэн гэх нийт 35 гомдол, мэдээлийг хүлээн авч Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газрын тусгай субъектийн үйлдсэн хэргийг мөрдөх хэлтэст харьяалуулан шалгуулахаар шилжүүлсэн. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч хоригдлыг зодсон, зүй бусаар харьцсан гэх 6 асуудал шалгалт хийх явцад илэрсэн. Үүнээс 2 гомдлын дагуу хорих анги албаны шалгалт явуулж, 2 гомдлыг Нийслэлийн прокурорын газрын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтэс шалгаж байгаа, 2 гомдлыг цагдаагийн байгууллагаас хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгасан. Гомдлын мөрөөр зөрчил дутагдлыг арилгуулж, Улсын Ерөнхий прокурор албан даалгавраар үүрэг, чиглэл өгсөн болно.

265. Цагдан хорих төв болон аймгууд дахь цагдан хорих байр, хорих ангийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналтын прокурор, Хүний эрхийн үндэсний комиссын ахлах мэргэжилтэн тогтмол хяналт тавин ажилладаг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 207 дугаар зүйлийн 207.9 дэх хэсэгт “Хоригдлын биед шарх, сорви, гэмтэл

бэртэл байгаа эсэх, хэрэв байгаа бол түүний хэлбэр, хүрээ, шинж байдлын талаар тэмдэглэлд тусгаж, гэрэл зураг, дүрс бичлэгийн хэрэгслийн тусламжтай бэхжүүлнэ. Хоригдлын биед үүссэн шарх, сорви, гэмтэл бэртэл нь аливаа хууль бус үйлдлийн улмаас үүссэн гэх үндэслэлтэй бол шалтгаан, нөхцөлийг тогтоох зорилгоор эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн шалгуулна” гэж заасны дагуу шийдвэрлэн ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2018 оны 12 дугаар сарын 12–ны өдрийн А/111 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Хорих, цагдан хорих, баривчлах төв, байранд хоригдож буй этгээдээс тухайн анги байрны үйл ажиллагаа, албан хаагчийн харилцаатай холбоотой гомдол, хүсэлтийг шууд хүлээн авах хайрцаг ажиллуулах журам” –ыг хэрэгжүүлснээр хоригдол, хоригдогч нарын эрх, эрх чөлөө зөрчигдөх, гаргасан гомдол хүсэлт дарагдах явдлаас сэргийлж чадсан.

*16(g)–Хорихоос өөр төрлийн арга хэмжээ (non-custodial measures) авах буюу хорих (detention)–оос өөр төрлийн сонголтот арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд анхаарал хандуулсан эсэх.*

266. Эрүүгийн хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Эрүүгийн хуулийн ялын бодлого, эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай хүнд аль болох хорих ял оногдуулахгүйгээр сонгох боломжтойгоор өөр төрлийн арга хэмжээ авах замаар нийгэмшүүлэхэд оршиж байна.

267. Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Эрүүгийн хариуцлага нь эрүүгийн хуульд заасан ял болон албадлагын арга хэмжээнээс бүрдэх бөгөөд Эрүүгийн хуулийн 6.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар эдгээр арга хэмжээ нь хүнлэг бус, хэрцгий, хүний нэр төр, алдар хүндийг гутаах шинжгүй байна.

268. Эрүүгийн хуулийн 5.5 дугаар зүйлд зорчих эрхийг хязгаарлах ялын талаар тусгасан. Гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрх бүхий байгууллагын хяналтад өөрийн оршин суух газраас явахыг хориглох, тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр оршин суух газраа өөрчлөх, зорчих үүргийг нэг сараас таван жил хүртэл хугацаагаар хүлээлгэхийг зорчих эрхийг хязгаарлах ял гэнэ.

269. Шүүх тухайн гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан ялтныг бусдад аюул учруулах эрсдэлтэй гэж үзвэл тодорхой хүнтэй, бусадтай харилцахыг хориглож болно. Ялтан зорчих эрхийг хязгаарлах ялыг биелүүлээгүй бол ялтны зорчих эрхийг хязгаарлах ялын эдлээгүй үлдсэн хугацааны нэг хоногийг хорих ялын нэг хоногоор тооцож хорих ялаар солино.

270. Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлийн 1.1, 1.2 дахь заалт, 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хөнгөн буюу хорих ялын дээд хэмжээг 5 жил, түүнээс доош хэмжээгээр тогтоосон гэмт хэрэг үйлдсэн бөгөөд гэм буруугаа сайн дураараа хүлээн зөвшөөрсөн, бусдад учруулсан хохирлоо нөхөн төлсөн, эсхүл нөхөн төлөхөө илэрхийлсэн хүнд хорих ялыг оногдуулахгүйгээр дээд тал нь 5 жил хүртэл хугацаагаар тэнсэж

тодорхой төрлийн үүрэг хүлээлгэх, зарим эрхийг хязгаарлах албадлагын арга хэмжээ авдаг.

271. Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлд хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх асуудлыг хуульчилсан. Хөнгөн гэмт хэрэг үйлдсэн хүн гэм буруугаа хүлээн зөвшөөрч гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлж хор уршгийг арилгасан, эсхүл гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн бол гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан Эрүүгийн хуулийн тухайн зүйл, хэсэг, заалтад заасан хорих ялыг оногдуулахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар тэнсэж болно.

272. Эрүүгийн хуулийн 8.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзсан, нийгэмд өөрийн байр суурийг олоход туслах, боловсрол эзэмшүүлэх, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн орчин, хүмүүсийн нөлөөнөөс тусгаарлах, шаардлагатай тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хорьж хүмүүжүүлэхэд чиглэсэн. Гэмт хэрэг үйлдэх үедээ 14 насанд хүрсэн боловч 18 насанд хүрээгүй хүнд ял оногдуулахгүйгээр Эрүүгийн хуульд заасан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болохоор хуульчилсан.

### **Цаазаар авах ялаар шийтгэгдсэн этгээдүүд**

*17.Хорооны гаргасан өмнөх ажиглалт дүгнэлт (21, 22 дахь параграф)–дзаасан дараах мэдээллүүдийг шинэчлэн ирүүлнэ үү.*

*17–1.Оролцогч Улс цаазаар авах ялыг хэрэглэхгүй байхаар шийдвэрлэсэн байдлыг харгалзан хүчингийн хэрэг болон хүн амины гэсэн хоёр гэмт хэрэгт цаазаар авах ял оногдуулах талаар Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Хууль зүй, дотоод хэргийн яаманд гаргасан саналын талаарх мэдээллийг шинэчлэн ирүүлнэ үү.*

273. Монгол Улсын Ерөнхийлөгч бага насны хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг нийгмийн өмнө тулгамдаж буй асуудал болж байгааг онцолж, Эрүүгийн хуульд цаазаар авах ялыг тусгах талаар арга хэмжээ авч, холбогдох хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх асуудлыг зохион байгуулах тухай саналыг Хууль зүй, дотоод хэргийн сайдад 2017 оны 11 дүгээр сарын 27–ны өдрийн Е/15 дугаартай албан бичгээр ирүүлсэн. Ерөнхийлөгчөөс тавьсан саналыг судалж Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 13–ны өдрийн А/299 тоот тушаалаар Монгол Улсын Засгийн газрын байр суурийг тодорхойлох чиг үүрэгтэй Ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд ахалж, бүрэлдэхүүнд эрдэмтэн, судлаачид, Гадаад харилцааны яам, Улсын Ерөнхий прокурорын газар, Хүний эрхийн үндэсний комисс, Монголын хуульчдын холбооноос төлөөлөл орж ажилласан.

274. Ажлын хэсэг нь олон улсын эрх зүйн үүднээс Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт II протоколыг соёрхон баталж, нэгдэн орсон улс энэ гэрээг хүчингүй болгох, гэрээгээр хүлээсэн үүргээсээ татгалзах, гэрээнээс гарах боломж байхгүй бөгөөд Монгол нь Улс Иргэний

болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт II протоколоор хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэх ёстой бөгөөд цаазаар авах ялыг Эрүүгийн хуульд сэргээн тусгах боломжгүй гэсэн дүгнэлт гаргасан юм.

275. 2018 онд дээрх байр суурийг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гадаад харилцааны сайд нар Европын Холбооноос Монгол Улсад суугаа болон хавсран суугаа Элчин сайд нартай уулзах үеэр илэрхийлсэн.

276. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гаргасан саналтай холбогдуулан НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газраас түүнд хандан албан захидал ирүүлснээс гадна иргэний нийгмийн төлөөлөл, эрдэмтэн судлаачид хэлэлцүүлэг зохион байгуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр байр сууриа илэрхийлэх зэргээр идэвхтэй үйл ажиллагаа явуулсан болно.

*17-2. Цаазаар авах ялыг хэрэглэхгүй байгаагийн улмаас өмнө нь цаазаар авах ял авсан байсан хүмүүст энэхүү Конвенцийн дагуу хамгаалалт санал болгосон эсэх тэр дундаа олон улсын стандартын дагуу цаазаар авах ял авсан байсан хүмүүсийг бусад хоригдлуудын нэг адил хорих хугацаанд тэдний үндсэн наад захын хэрэгцээг хангахуйц нөхцөл байдалд байлгадаг эсэх талаар тодруулна уу.*

277. Монгол Улсын Их Хурлаас Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг шинэчлэн баталж 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөнтэй холбогдуулан 30 жилийн хорих ялтай хоригдлууд хуулийн тэгшитгэлд хамрагдан, ялын хугацаа нь 20 жил болж, хорих ял эдлэх хорих ангийн дэглэм зэрэглэлийг хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд ял эдлэх болж өөрчлөлт орсон.

278. Цаазаар авах ялаар шийтгүүлж, уучлалд хамрагдан 30 жилийн хорих ял эдэлж байсан 34 хоригдлоос 2 хоригдлын хорих ялын хугацаа дуусч суллагдсан. 32 хоригдлын хорих ял 20 жил болж, хаалттай хорих ангид хорих ялыг эдлүүлэхээр хорих ангийг өөрчилсөн. 2018 онд 1, 2019 онд 1 хоригдол хорих ялаас хугацааны өмнө тус тус суллагдсан.

*17-3.Өмнө нь цаазаар авах ял авсан байсан хүмүүст ялыг 30 жилийн хугацаатай хорих ялаар өөрчилж, үүнээс 10 жилийг ганцаарчлан хоригдох нөхцөлтэй байлгаж байгаа эсэх талаар тодруулж дурдана уу.*

279. 2015 онд батлагдсан Эрүүгийн хуульд цаазаар авах ялыг бүрмөсөн халж хуульчилсан. 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс тус хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Цаазаар авах ял шийтгүүлсэн хүмүүсийн ял уг хуулийн дагуу 20 жилийн хугацаатай хорих ялаар солигдож, тэдгээр хоригдлууд бусад хоригдлуудын адил нөхцөлд хорих ял эдэлж байна.

*17-4. 2015 онд цаазаар авах ялаар шийтгүүлсэн хоёр хүний талаарх мэдээллийг гаргаж өгнө үү.*

280. Б.Б нь анх удаагийн ял шүүхийн 2015 оны 09 дүгээр сарын 09–ний өдрийн шийтгэх тогтоолоор 2002 оны Эрүүгийн хуулийн 91<sup>43</sup> дүгээр зүйлийн 91.2.11, 91.2.12 дахь заалтад заасны дагуу цаазаар авах ялаар шийтгэгдсэн. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 02 дугаар сарын 22–ны өдрийн 176 дугаар шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.11, 91.2.12 дахь заалтын дагуу нийт 25 жилийн (10 жил гянданд, 15 жил онцгой) хорих ялаар өөрчлөн шийтгэгдсэн. Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 4 дүгээр сарын 14–ны өдрийн 239 дүгээр магадлалаар цагдан хоригдсон 898 хоногийг 927 хоног болгон өөрчилсөн. Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 7 дугаар сарын 03–ны өдрийн 191 дүгээр захирамжаар 2015 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2.1, 10.1.2.5–д заасны дагуу ялыг 20 жилээр дүйцүүлэн тогтоосон. 2019 оны 11 дүгээр сарын 15–ны өдөр 415 дугаар хаалттай хорих ангид шилжүүлсэн. Хорих ял эдлэх хугацаандаа уран зургийн дугуйланд хамрагдаж байсан. Одоогоор хөдөлмөрт хуваарилагдаагүй байна. Бусдад төлөх төлбөргүй.

281. О.Э анх удаагийн ял шийтгэлтэй. 2015 оны 3 дугаар сарын 20–ны өдрийн шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.2, 91.2.3, 91.2.12, 91.2.13, 91.2.16–д тус тус зааснаар цаазаар авах ялаар шийтгүүлсэн. 2015 оны 4 дүгээр сарын 27–ны өдөр Хөвсгөл аймаг, Мөрөн сум Эрүүгийн хэргийн давж заалдах шүүхийн 24 дүгээр магадлалаар цаазаар авах ялыг 25 жилийн хорих ял болгон өөрчилсөн. 2017 оны 7 дугаар 04–ний өдөр Эрүүгийн хуулийн өөрчлөлтөөр ЭХ–ийн 10 дугаар зүйлийн 10.1.2.1–д зааснаар ялыг 20 жил болгосон. 2019 оны 4 дүгээр сарын 01–ний өдөр 435 дугаар хаалттай хорих ангид шилжүүлсэн. Тус хорих ангид ирсэн цагаасаа хойш ангийн гар урлалын цехэд мужаан хуваарьтайгаар ажиллаж байна. Бусдад төлөх 12,876,786 төгрөгийн төлбөртэй.

## 12–13 дугаар зүйл

*18. Тайлангийн хугацаанд Оролцогч Улсын эрх бүхий байгууллагын зүгээс бүртгэсэн ноцтой хэмжээний хүч хэрэглэсэн, эрүүдэн шүүсэн, зүй бус хүнлэг бус харьцсан гэх үйлдлүүдийн талаар гаргасан гомдлын талаарх статистик мэдээллийг шинэчлэн гаргаж өгнө үү. Уг мэдээлэлд гомдлын мөрөөр мөрдөн шалгасан, хариуцлага хүлээлгэхдээ сахилга хүлээлгэх асуудлыг авч үзсэн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийгдсэн, мөн сахилгын болон эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн эсэх талаарх мэдээллийг оруулна.*

282. Тайлангийн хугацаанд тус улсад ноцтой хэмжээний хүч хэрэглэсэн, эрүүдэн шүүсэн, зүй бус харьцсан гэх хэргийн тухайд нийгэм, улс төрийн зүтгэлтэн С.Зоригийн амь насыг хөнөөсөн хэрэгт ял шийтгэгдсэн Б.С, Т.Ч нарт мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа, эрүү шүүлт тулгасан гэх хэргийн мөрдөн шалгах ажиллагааг дуусгаж, шүүхэд шилжүүлсэн бөгөөд шүүхээс хэргийг эцэслэн шийдвэрлээгүй байна”

---

<sup>43</sup> АРВАНТАВДУГААР БҮЛЭГ. ХҮНИЙ АМЬ БИЕ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ (91 дүгээр зүйл. Хүнийг санаатай алах)

283. Дээрх хэргээс гадна тайлангийн хугацаанд эрүү шүүлт тулгах гэмт хэргээр буруутгагдан ял шийтгэсэн нийт 4 хэргийг шүүх шийдвэрлэжээ. Тухайлбал 2016 онд 1 хэргийг, 2019 онд 3 хэргийг шийдвэрлэсэн байна. Шүүх хурлыг нээлтэй хийсэн бөгөөд шүүхийн шийдвэрүүд шүүхийн цахим санд бүрэн эхээр тавигдсан болно.

284. 2020 оны 09 дүгээр сарын 04–ний өдрийн байдлаар Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд заасан эрүү шүүлт тулгах гэмт хэрэг үйлдсэн нийт 2 хоригдол ял эдэлж, 7 хоригдогч анхан шатны шүүхээр ял шийтгүүлэн хоригдож байгаа ба уг гэмт хэргийн улмаас учирсан хохирол, төлбөр байхгүй байна.

#### **14 дүгээр зүйл**

##### **Хохирол барагдуулах буюу нөхөн төлбөр болон нөхөн сэргээх**

*19. Хорооноос өмнө өгсөн ажиглалт дүгнэлт (39, 40 дэх параграф)–н дагуу дараах мэдээллийг гаргаж өгнө үү.*

*19–1 Эрүүдэн шүүгдсэн, зүй бус, хүнлэг бус харьцсаны улмаас хохирсон хохирогчдод зохих нөхөн төлбөр, нөхөн олговор өгөх талаар зохицуулсан шинэ хууль тогтоомж батлагдсан эсэх тухай мэдээллийг шинэчлэн гаргаж өгнө үү.*

285. 2006 онд батлагдсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу 2011 онд Засгийн газрын 132 дугаар тогтоолоор “Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох журам”–г баталсан.

286. Засгийн газрын 2018 оны 143 дугаар тогтоолоор дээрх журамд өөрчлөлт оруулж тус сангийн хөрөнгийг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн, Эрүүгийн хуульд заасан 10 төрлийн гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, хүнд гэмтэл учирсан хохирогчид нөхөн төлбөр олгоход зарцуулна. Тодруулбал 10.1 дүгээр зүйл /Хүнийг алах/, 11.1 дүгээр зүйл /Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах/, 12.1 дүгээр зүйл /Хүчиндэх/, 13.3 дугаар зүйл /Хүн барьцаалах/, 13.4 дүгээр зүйл /Хүнийг хүчээр алга болгох/, 17.2 дугаар зүйл /Дээрэмдэх/, 19.3 дугаар зүйл /Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах/, 21.12 дугаар зүйл /Эрүү шүүлт тулгах/, 29.1 дүгээр зүйл /Түрэмгий дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх/, 29.8 дугаар зүйл /Террорист үйлдэл хийх/ зэрэг болно. Эрүүдэн шүүгдсэн, зүй бус, хүнлэг бус харьцсаны улмаас хохирсон хохирогчдод нөхөн төлбөр олгох асуудлыг дээрх журмаар зохицуулсан.

287. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг 2019 онд шинэчлэн найруулж баталсан. Тус хуулийн 10 дугаар зүйлд гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн талаар шинэлэг зохицуулалтыг тусгасан. Өмнө дурсан 10 төрлийн гэмт хэргийг өргөжүүлж, нэмж 11<sup>44</sup> хэргийг хуульд тусгаж заасан гэмт хэргийн улмаас амь насаа

<sup>44</sup> Эрүүгийн хуулийн 11.4 дүгээр зүйл /Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах/, 12.3 дугаар зүйл /Бэлгийн мөлжлөг/, 13.1 дүгээр зүйл /Хүн худалдаалах/, 13.2 дугаар зүйл /Хүн хулгайлах/, 15.3 дугаар зүйл /Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах/, 15.5 дугаар зүйл /Хууль бусаар үр хөндөх/, 16.1 дүгээр зүйл /Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах/, 16.3 дугаар зүйл /Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх/, 16.6 дугаар зүйл /Хүүхэд худалдах/, 16.7 дугаар зүйл /Хүүхэдтэй хэрцгий харьцах/, 16.11 дүгээр зүйл /Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх/



алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, түүнчлэн хүнд гэмтэл учирсан хохирогчийн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрт заасан дараах хохиролд нөхөн төлбөр олгоход зарцуулахаар дээрх хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт хуульчилж өгсөн.

*19–2 Тайлангийн хугацаанд шүүхийн шийдвэрийн дагуу хохирогчдод нөхөн төлбөр, нөхөн олговор олгуулахаар авч буй арга хэмжээний талаар тэр дундаа эрүүдэн шүүгдсэн хохирогчдыг болон тэдний гэр бүлийнхнийг нөхөн сэргээх талаар авсан арга хэмжээний талаар мэдээлэл өгнө үү. Уг мэдээлэлд гаргасан гомдлын тоо, шийдвэрлэгдсэн гомдлын тоо, гомдол тус бүрийн дагуу авсан арга хэмжээ, шийдвэрийн дагуу олгогдсон нөхөн төлбөрийн хэмжээ, эрүү шүүлтэд өртсөн хохирогч эрүүл мэндийн болон сэтгэл зүйн туслалцаа авсан хэргийн тоог оруулна.*

288. Эрүүгийн хэрэгт шалгагдаж, үндэслэлгүйгээр цагдан хоригдсон, цагаатгагдсан иргэдээс учирсан хохирлыг төрөөс нэхэмжилсэнтэй холбоотойгоор 2016–2019 онуудад 45 иргэнд 662.7 сая төгрөгийг, 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар 1 иргэнд 3.9 сая төгрөгийг улсын төсвөөс олгосон байна.

289. Эрүү шүүлтэд өртсөн хохирогч эрүүл мэндийн болон сэтгэл зүйн туслалцаа авсан хэргийн тоо өнөөдрийн байдлаар 1 байна. (Тайлангийн 274 дэх хэсгийг үзнэ үү.) Эрүү шүүлтэд өртсөн хохирогч Б.С, Т.Ч нарт эрүүл мэндийн болон сэтгэл зүйн туслалцааг зохих ёсоор үзүүлсэн. 401 дүгээр хаалттай хорих анги буюу нэгдсэн эмнэлэгт Б.С, Т.Ч нар нь 2019 оны 03 дугаар сарын 20–ны өдрөөс эмчилгээнд хамрагдан ял эдэлж байгаа ба сэтгэцийн эмч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтнууд тогтмол хяналт тавин сэргээн засах үйлчилгээ үзүүлж байна. Одоогоор хохирогч нар нь сэтгэл зүйн байдал тайван, сэтгэцийн ямар нэг асуудалгүй, хорих байгууллагын үйл ажиллагаанд гомдол, саналгүй байна.

*19–3 Эрүү шүүлт, зүй бус, хүнлэг бус харьцааны улмаас хохирсон хохирогчдыг эдгээх, нөхөн сэргээхэд чиглэсэн тэр дундаа гэмтэл бэртэлтийг эмчлэх, өөр бусад хэлбэрээр эргэж хэвийн байдалд оруулахад анхаарсан одоогоор хэрэгжүүлж буй аливаа хөтөлбөрийн талаарх мэдээлэл, мөн уг хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хуваарилсан материаллаг, хүний нөөцийн, санхүүгийн нөөцийн талаарх мэдээллийг гаргаж өгнө үү.*

290. Эрүү шүүлт, зүй бус, хүнлэг бус харьцааны улмаас хохирсон хохирогчдыг эдгээх, нөхөн сэргээхэд чиглэсэн тэр дундаа гэмтэл бэртэлтийг эмчлэх, өөр бусад хэлбэрээр эргэж хэвийн байдалд оруулах чиглэлээр одоогоор хэрэгжүүлж буй хөтөлбөр байхгүй болно.

**15 дугаар зүйл**

*20. Шүүхийн үйл ажиллагаанд эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бусаар харьцсаны үр дүнд олж авсан баримт мэдээлэл, нотлох баримтын талаар мэдээлэл гаргаж ирүүлнэ үү.*

*20-1. Шүүхийн үйл ажиллагаанд эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бусаар харьцсаны үр дүнд олж авсан баримт мэдээлэл, гэм буруугаа хүлээсэн байдлыг нотлох баримтаар ашиглахгүй байхыг нягтлах талаар Оролцогч Улсын зүгээс авсан тодорхой арга хэмжээнүүдийг дурдана уу.*

291. Эрүү шүүлт тулгаж авсан нотлох баримтыг нотлох баримтын хэмжээнд үнэлэхгүй, түүнчлэн яллагдагч, шүүгдэгч өөрөө хэргээ хүлээсэн нь хэрэгт авагдсан бусад нотлох баримтуудаар зайлшгүй нотлогдсон байхыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааж өгсөн. Эрүү шүүлт тулгаж авсан нотлох баримтыг нотлох баримтаар тооцохгүй байхыг хуульчлан тус хуулийн 16.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Эрүү шүүлт тулгаж, бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий харьцаж мэдүүлэг авсан нь тогтоогдвол авсан мэдүүлгийг нотлох баримтаар тооцохгүй” гэж тусгайлан заасан.

292. Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд заасан эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд шүүх Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан мэдүүлгийг нотлох баримтаар тооцож болно.

293. Нотлох баримтаар тооцохгүй байх нийтлэг журмыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.11 дүгээр зүйлд тусгасан. Өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгсөн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлгийг нотлох баримтаар тооцохгүй байх тухай прокурорын санал, оролцогчийн хүсэлтийг шүүх хянан хэлэлцэж, тухайн нотлох баримтыг нотлох баримтад тооцохгүй байх эсэхийг шийдвэрлэнэ.

294. Хуульд заасан үндэслэл, журмыг зөрчин цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцэж байгаа эсэхийг харгалзан бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нь, тодорхой мөрдөн шалгах ажиллагаагаар цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтын заримыг нотлох баримтаар тооцохгүй байх тухай прокурорын санал, оролцогчийн хүсэлтийг шүүх хянан хэлэлцэж шийдвэр гаргана. Шүүх нь: 1/ прокурорын санал, оролцогчийн хүсэлтийг хүлээн авахаас татгалзах; 2/ бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нотлох баримтаар тооцохгүй байх; 3/ тодорхой мөрдөн шалгах ажиллагаагаар цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтын заримыг нь нотлох баримтаар тооцохгүй байхаар шийдвэрлэнэ.

295. Дээрх хуулийн зохицуулалтын хүрээнд мөрдөн шалгах чиг үүрэгтэй байгууллагуудын хувьд хамгийн дутагдалтай байсан тал буюу хэрэг хүлээлгэхийн тулд гэм бурууг өөрөөр нь хүлээлгэхэд суурилсан арга барил өөрчлөгдөж байна. Гэмт хэрэгт буруутгагдаж байгаа этгээд өөрөө гэм буруугаа хүлээгээгүй бол хэргийг шүүхээс мөрдөн шалгах шат руу буцаадаг хандлага мөн өөрчлөгдсөн. Түүнчлэн нотлох баримтад суурилсан арга барилыг нэвтрүүлэхэд анхаарч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3 дахь зүйлд заасны дагуу сэжигтэн, яллагдагч нараас мэдүүлэг авахдаа өөрсдийнх нь сонгосон өмгөөлөгчийг байлцуулах, мэдүүлэг авахад зориулан тусгайлан бэлдсэн өрөөнд мэдүүлэг авч байна.

296. Энэ чиглэлээр мөрдөн шалгах чиг үүрэгтэй байгууллагуудын алба хаагчдыг сурган дадлагажуулахад анхаарч, сургалтын хөтөлбөрийг боловсруулахад анхаарч эхэлсэн. Тухайлбал: 2019 онд Цагдаагийн ерөнхий газраас “Эрүү шүүлтийн хохирогчдын нөхөн олговор, нөхөн сэргээлт, хохирол барагдуулалтын өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудал” зэрэг сэдвүүдийг бэлтгэж сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд нэмэлтээр тусгасан байна.

*20–2. Тайлангийн хугацаанд эрүү шүүлт тулган олж авсан баримт мэдээлэл, гэм бурууг өөрөөр нь хүлээлгэсэн байдлыг нотлох баримтаар шүүхээс тооцсон хэргийн тоо, нотлох баримтаар тооцоогүй хэргийн тооны талаар мэдээлэл өгнө үү.*

297. Цаашид энэ чиглэлээр судалгаа тогтмол хийх шаардлагатай байна.

*20–3. Гэм бурууг нь өөрөөр нь хүлээлгэхэд тулгуурласан байцаалтын аргаас нотлох баримтад үндэслэн яллах ажиллагаа явуулах арга хэрэглэхэд шилжихийн тулд Оролцогч Улсаас авсан аливаа тодорхой арга хэмжээний талаар мэдээлэл гаргаж ирүүлнэ үү.*

298. Эрүүгийн хуульд яллагдагч, шүүгдэгчийн гэм буруугаа хүлээлгэсэн мэдүүлэг нь дангаараа гэм буруутайд тооцох нотлох баримтад тооцогдохгүй байх зарчмыг тусгасан нь тун чухал ахиц болсон. Тодруулбал Эрүүгийн хуулийн 1.7 дугаар зүйлийн 4–т зааснаар шүүх, прокурор, мөрдөгч нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс гэм буруугүй болохыг өөрөөр нь нотлуулахаар шаардахыг хориглоно. Мөрдөн шалгах чиг үүрэгтэй байгууллагуудаас гадна прокурорын байгууллагын алба хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх сургалтууд явуулахад анхаарч байна. Тухайлбал: Эрүү шүүлт тулгах, эрүүдэн шүүхээс ангид байх чиглэлээр “Азийн зарим улсын эрүүдэн шүүхийн эсрэг тэмцэж байгаа туршлагаас хуваалцах нь” сэдэвт сургалтыг зохион байгуулж, Улсын Ерөнхий прокурорын газрын, нийслэлийн, дүүргийн прокурорын газрын прокурорууд болон Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн алба, Авилгатай тэмцэх газрын нийт 60 албан хаагч хамрагдсан байна.

299. Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх сургалт, судалгааны төвөөс энэ чиглэлээр сургалт тогтмол зохион байгуулж байна. Сургалтанд хамрагдсан нийт прокурор, ажилтнуудаас авсан сургалтын талаарх санал, хүсэлтийг судалж үзэхэд эрүүдэн шүүх тулгах болон хүний эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэргийг шалган шийдвэрлэх талаарх сургалтанд түлхүү хамрагдах, сургалтын гарын авлага, аргачлал гаргуулах талаарх саналууд их ирсэн. Үүний дүнд хүний эрхийн болон эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаарх олон улсын гэрээ, бусад баримт бичгийн эмхтгэлийг боловсруулан ном болгон гаргаж прокурорын газруудад болон бусад байгууллагад тараасан байна.

**16 дугаар зүйл**

**Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийлэл**

*21. Хорооноос өмнө өгсөн ажиглалт дүгнэлт (27 болон 28 дахь параграф)–н дагуу дараах мэдээллийг шинэчлэн гаргаж өгнө үү.*

*21(a) Эрүүгийн хуульд гэрлэлтийн хүчинг гэмт хэрэгт тооцох талаар аливаа нэмэлт, өөрчлөлт орсон эсэх;*

300. Эрүүгийн хуульд гэрлэлтийн хүчинг тусгайлан гэмт хэрэг болгон зүйлчлээгүй. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд гэр бүлийн хүчирхийллийн төрлийг тодорхойлсон. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд орсон тодорхойлолт дахь бэлгийн хүчирхийллийн төрөлд гэрлэлтийн хүчин багтсан болно.

301. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1–д заасны дагуу “гэр бүлийн хүчирхийлэл” гэж энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхгүйг хэлнэ гэж тодорхойлж, гэр бүлийн хүрэн дэх бэлгийн эрх чөлөөг хамгаалсан болно. Тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1–д заасны дагуу “эхнэр, нөхөр, хамтран амьдрагч” нь хуулийн үйлчлэлд хамаарах этгээд юм. Тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “гэр бүлийн хүчирхийлэл нь бие махбодын хүчирхийлэл, сэтгэл санааны хүчирхийлэл, эдийн засгийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл” гэсэн хэлбэрээр үйлдэгдэхийг зааж “гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээд эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүнийг бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг бэлгийн хүчирхийлэл гэнэ” гэж тодорхойлсон.

302. Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлд “хоширогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харьцаанд орсон, эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн үйлдлийг хүчиндэх гэмт хэрэг” гэж хуульчилсан. Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 2.3 дахь заалтад “гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэж” үйлдсэн бол хүндрүүлэх нөхцлөөр тооцож таваас арван хоёр хүртэл жилийн хорих ял оногдуулахаар заасан болно.

*21(b) Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчийн гаргасан гомдлыг хүлээн авах бие даасан, үр дүнтэй механизмыг бий болгох чиглэлээр авсан арга хэмжээ, мөн гэр бүлийн хүчирхийллийн тэр дундаа бэлгийн хүчирхийлэл, гэрлэлтийн хүчин, хүүхдийн эсрэг хүчирхийлэл зэрэг гэмт хэргийг цагдаагийн байгууллага бүртгэж буй эсэх, түүнчлэн эдгээрийг даруй мөрдөн шалгаж буй эсэхийг нягтлах;*

303. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А301 дүгээр тушаалаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтсийг шинээр байгуулсан. Хэлтсийн үндсэн зорилго нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, энэ төрлийн гэмт

хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх явдал юм. Түүнчлэн бүх цагдаагийн газар, хэлтэст гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн ажиллаж байна.

304. Нийслэлийн цагдаагийн газрын харьяа түр хамгаалах байранд Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээлэл хүлээн авах “107” тусгай дугаарын утас ажиллаж байна. 107 тусгай дугаараар гэр бүлийн хүчирхийллийн талаархи бүх төрлийн мэдээлэл дуудлагыг авдаг. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эсвэл хүчирхийлэлд өртөх магадлалтай хохирогч, түүний бага насны хүүхдийг хамгаалах ажлыг Нийслэлийн цагдаагийн газрын харьяа тус Түр хамгаалах байранд явуулж байна. Энэ төв нь 24 цагаар үйл ажиллагаа явуулж хохирогчдыг 3-аас 10 хоног байрлуулан тэдэнд сэтгэл зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлж байна.

305. Цагдаагийн байгууллагын бүх шатны алба хаагч хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийн талаар дуудлага, мэдээлэл авсан даруй газар дээр нь очиж, аюулын зэргийн үнэлгээ хийх, хүчирхийллийг таслан зогсоох, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах хангалттай мэдлэг, чадавхитай болсон.

306. 2015 онд батлагдсан Эрүүгийн хууль нь 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Шинээр батлагдсан ч хүчин төгөлдөр хэрэгжиж эхлээгүй байсан тул 2002 оны Эрүүгийн хуульд 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр нэмэлт оруулсан. 2002 оны Эрүүгийн хуулийн 120<sup>1</sup> дүгээр зүйлээр “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” хэргийг хуульчилсан. 2015 оны Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг хуульчилсан.

307. 2002 оны Эрүүгийн хуулийн 120<sup>1</sup> дүгээр зүйлд гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодсон, харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэхээр заасан байсан.

308. 2015 оны Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд зааснаар гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга 1/зодсон; 2/харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан; 3/хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

309. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн бол зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

310. Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2.8 дахь заалтад хүнийг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж алсан бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэхээр хуульчилсан.

311.3 өрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлд гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдэд 7-оос 30 хүртэл хоног баривчлах шийтгэл ногдуулж, албадан сургалтад суулгахаар заасан. Үүнээс өөр торгох гэх мэт бусад төрлийн шийтгэл байхгүй. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн шинжгүй гэр бүлийн хүчирхийллийг мөрдөн шалгаад зөрчил

тогтоогдвол зөвхөн баривчлах шийтгэл оногдуулна.

312. Цагдаагийн байгууллагын дуудлага мэдээллийн бүртгэлийн системд 2018 онд гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээллийн нэгдсэн сан (eGBV)–г шинээр бий болгож, үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус нэгдсэн систем нь тусгай дугаарын “102” утсанд бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн тэр дундаа хүчирхийлэлтэй орчинд амьдарч байж болзошгүй хүүхдүүдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүчирхийлэл үйлдэгдсэн талаарх мэдээллийн давтамж, нөхцөл байдлыг урьдчилан дүн шинжилгээ хийхэд зориулсан болно.

313. 2017 онд Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан зүйлчлэлээр 223 хэргийг бүртгэн, мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас хэрэгсэхгүй болгосон 81 хэрэг бүртгэлтийн хэрэг, яллах дүгнэлт үйлдүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн 132 хэрэг, нэгтгэсэн хэрэг 10 байсан.

314. 2018 онд Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан зүйлчлэлээр 210 хэргийг бүртгэн, мөрдөн шалгах ажиллагаа явуулж, үүнээс 34 хэрэг бүртгэлтийн хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэн, яллах дүгнэлт үйлдүүлэх саналтай 165 хэргийг прокурорт шилжүүлсэн байна. 11 хэргийг нэгтгэсэн.<sup>45</sup> Прокуророос 2 хэргийг нэгтгэж, 163 хэрэгт яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн.

315. 2019 онд шинээр 207 хэрэг бүртгэж, 17 хэргийг хэрэгсэхгүй болгон, 8 хэргийг нэгтгэсэн ба ажиллагаанд 24 хэрэг, 148 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр санал гарган прокурорт шилжүүлсэн. Үүнээс прокурор 97 хэргийг хааж, 6 хэргийг хэрэгсэхгүй болгож, 45 хэргийг нэгтгэж шүүхэд шилжүүлсэн.

316. 2020 оны эхний есөн сарын байдлаар цагдаагийн байгууллага гэр бүлийн хүчирхийллийн 253 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсанаас 63 хэргийг хааж, 4 хэргийг хэрэгсэхгүй болгож, 7 хэргийг нэгтгэж, 179 хэрэгт яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн байна.

317. Нэг талаас цагдаагийн байгууллага гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийг мөрдөн шалгах шатанд нь илрүүлж, шалгаж, шийдвэрлэх чадавхитай болсон байна. Нөгөө талаас энэ төрлийн хэрэг, зөрчлийг иргэд маш сайн мэдээлдэг болжээ.

*21(с) Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчийг хамгаалах талаар тайлангийн хугацаанд авсан тодорхой арга хэмжээ тэр дундаа аливаа хязгаарлалт тавьсан шийдвэр гаргасан байдал, Оролцогч Улсад шинээр хамгаалах байр зэрэг баригдсан эсэх;*

318. Гэр бүлийн хүчирхийлэл гарахаас урьдчилан сэргийлэх, хохирогчдыг хамгаалах чиглэлээр Хууль зүй, дотоод хэргийн яам болон бусад төрийн байгууллагууд хуульд заасан чиг үүргийн хүрээнд ажиллаж байна. Тухайлбал: Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Шүүх эмнэлгийн дэргэдэх Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөгсдөд үйлчлэх Нэг цэгийн төвд хохирогчдод эмнэлгийн болон сэтгэл зүйн туслалцааг “1222” тусгай дугаарын утсаар үзүүлж байна.Түүнчлэн хүчирхийллийн

<sup>45</sup> Эх сурвалж: Монгол Улс дахь цагаан ном 2016, 2017, 2018

хохилогчдод үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх [www.etuslamj.mn](http://www.etuslamj.mn) портал цахим хуудсыг шинээр бий болгосон.

Гэр бүлийн хүчирхийллийн хохилогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор түүнийг түр хамгаалах байранд байрлуулж, үйлчилгээ үзүүлэхэд баримтлах “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардал тооцох журам”-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/150 дугаар тушаалаар батлуулсан.

319. Монгол Улсын хэмжээнд нэг цэгийн үйлчилгээний төвийн тоо 2016 онд 8, 2017 онд 10, 2018 онд 11, 2019 онд 15, 2020 онд 18 ажиллаж байна. Хамгаалах байрны тоо 2016 онд 3, 2017 онд 6, 2018 онд 9, 2019 онд 14, 2020 онд 13 ажиллаж байна.

320. Ковид-19 цар тахлын улмаас тогтоосон хөл хорионы хугацаанд хүчирхийллийн хохилогчид үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төв болон түр хамгаалах байранд үйлчлүүлсэн иргэдийн тоо 87 хувиар өссөн. Иймд Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 52 дугаар тушаалын дагуу Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй гэр бүлийн хүчирхийллийн хохилогчийг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх 9 түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Улсын онцгой комиссоос 1,000,000,000 төгрөг (3,544,087.6 ам.доллар)-ийг олгосон байна.

*21(d) Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохилогчийн эмзэг байдлын талаар мөн эдгээр үйлдлийг гэмт хэрэгт тооцсон хууль тогтоомжийн тухай цагдаагийн албан хаагчид, бусад хууль сахиулах байгууллагын ажилтнууд, шүүгч, прокурор, эмнэлгийн болон нийгмийн ажилтнуудыг сургалтад хамруулсан эсэх;*

321. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/27 дугаар тушаалаар улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үүрэг бүхий Дэд зөвлөлийг байгуулсан. Дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд хуулиар чиг үүрэг хүлээсэн бүх салбарын яамд, агентлаг, төрийн бус байгууллагуудын төлөөлөл багтдаг. Орон нутгийн хэмжээнд Баянхонгор, Дорнод, Завхан аймаг, нийслэлийн Баянзүрх дүүргүүдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлүүдийг тус тус байгуулсан.

322. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд олон талт хамтын ажиллагаа” сэдэвт үндэсний чуулганыг 2017 оноос хойш жил бүр зохион байгуулсан. Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, Эрүүл мэндийн газрын дарга, Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, цагдаагийн алба хаагчид зэрэг нийт 200 хүнийг оролцуулж, хуулийн хэрэгжилт, үр дүн, хүндрэл бэрхшээлийн шийдлийг хэлэлцэж хэвшсэн.

323. Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллагатай хамтран гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тэмцэхэд хууль зүйн салбарын чадавх, уялдаа холбоог бэхжүүлэх сургалтыг 2017–2019 онуудад зохион байгуулж, нийслэл, дүүрэг, 21 аймгийн цагдаа, прокурор, шүүгч, өмгөөлөгч, нийгмийн ажилтан, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Салбар зөвлөлийн гишүүн нар тус бүр 1000 хүнийг хамруулан мэдлэг, үр чадварыг нь дээшлүүлсэн.

324. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйлд “хамтарсан баг”-ийн талаар зохицуулсан. Хамтарсан баг нь гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах, хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, хүчирхийллийг таслан зогсоох үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх, нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хохирогчид үзүүлэх үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ. Түүнчлэн хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн халамж, үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай бусад үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах, хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн сургалт, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах, гэр бүлд нь дэмжлэг үзүүлэх замаар нөхөн сэргээж, нийгмийн амьдралд оролцох оролцоог дээшлүүлэх, хохирогчид үзүүлсэн үйлчилгээний талаархи статистик мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлэх үйлчилгээг мөн үзүүлнэ.

325. Хамтарсан багт ажиллах үүрэг хүлээсэн сум, дүүргийн Засаг даргаар ахлуулсан өрхийн эмч, хэсгийн төлөөлөгч, сургуулийн нийгмийн ажилтан болон нийгмийн ажилтан зэрэг албан хаагчдыг сургах, дахин сургах зорилгоор хамтарсан багийн үндэсний сургагч бэлтгэх сургалтыг 2017, 2019 онуудад зохион байгуулсан. 21 аймаг, 9 дүүрэг дэх Хамтарсан багийн нийт гишүүдийн тоо жил ирэх тутам өсч байна. Тухайлбал: 2017 онд 609, 2018 онд 4634 гишүүдтэй байсан бол 2019 онд нийт 676 хамтарсан баг болж өсч, гишүүдийн тоо 4714 болж нэмэгдсэн.

326. Хамтарсан багийн туршлага судлах сургалт, уулзалтыг 2018 оны 06 дугаар сард Улаанбаатар хотод зохион байгуулж, Баян-Өлгий, Баянхонгор, Говьсүмбэр, Завхан, Сэлэнгэ, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн Хамтарсан багийн 154 гишүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, сайн туршлага бүхий Хамтарсан багийн үйл ажиллагаатай танилцаж туршлага судлах арга хэмжээг зохион байгуулав. Мөн “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд сум, дүүргийн засаг дарга, хэсгийн ахлагчийн үүрэг, оролцоо” сэдэвт сургалтыг 2018 оны 06 дугаар сард улсын хэмжээнд зохион байгуулж 3599 сум, хорооны багийн дарга, хэсгийн төлөөлөгч нарыг хамруулав.

327. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангаас 2017 онд “Монгол дахь жендэрт суурилсан хүчирхийлэл тэр дундаа гэр бүлийн хүчирхийллийн тархалтын судалгаа”-г 7300 эмэгтэйчүүдийн дунд хийж, эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэж буй хүчирхийллийн түвшинг тогтоосон. Уг судалгааны дүнд үндэслэн 2018, 2019 онуудад гэр бүлийн хүчирхийлэл хамгийн их үйлдэгдсэн, хохирогч хамгааллын тогтолцоо хамгийн их шаардлагатай Баян-Өлгий, Дархан-Уул, Дорнод, Өвөрхангай, Өмнөговь, Хөвсгөл, Хэнтий аймаг, нийслэлийн Баянзүрх, Хан-Уул дүүргүүдэд гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвийг шинээр байгуулсан. Эдгээр төвийг шинээр байгуулахад орон нутгийн төсвөөс 623 сая төгрөг, олон улсын байгууллагаас 764,5 сая төгрөг тус тус зарцуулсан.

328. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт хангах ажлыг эрчимжүүлэх зорилгоор Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, НҮБ-ын Хүн амын сантай хамтран 2018 онд “Гэр бүлийн



хүчирхийлэлтэй тэмцэхэд олон талт хамтын ажиллагаа” сэдэвт нийт 4 бүсийн зөвлөгөөнийг зохион байгуулсан. Үүний үр дүнд зэргэлдээ аймгуудын гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хамгааллын хамтын ажиллагаа сайжирч, нарийн мэргэжлийн мэргэжилтнүүд солилцох, мөн дагалдуулан сурган ажиллах боломж бүрдсэн.

329. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн талаарх мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх үүднээс 2018 онд цагдаагийн байгууллагын 1675 алба хаагчдын дунд 25 удаагийн, 2019 онд цагдаагийн байгууллагын 2995 алба хаагчдын дунд 37 удаагийн, нийт 62 удаагийн сургалт зохион байгуулсан.

330. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдыг мэргэшүүлэх, чадавхижуулах үүднээс 2019 онд нийт 49 алба хаагчдад бие хүний сэтгэл зүйн үндсэн асуудал, хүний зан үйлд нөлөөлөх сэдвээр сургалт зохион байгуулж, сургагч багш нар бэлтгэж гэрчилгээ олгосон.

331. Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Дотоод хэргийн их сургуулийн хичээлийн хөтөлбөрт сонгон үзэх байсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” сэдэвт хичээлийг 2019 оны хичээлийн жилээс эхлэн заавал үзэх хичээл болгон сургалтын хөтөлбөрт тусгасан.

*21(е) Гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой гомдлын тоо, мөрдөн шалгалт хийсэн, прокурорын хяналтад орсон хэрэг тохиолдлын тоо, энэ төрлийн хэрэгт ял шийтгэл хүлээлгэсэн байдал, хүлээлгэсэн ял шийтгэл, хохирогчийн нас, угсаа гарал, гэмт хэрэг үйлдэгчидтэй ямар холбоотой байсан эсэх статистик мэдээлэл.*

332. Улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2017 онд үйлдэгдсэн гэмт хэрэг нийт хэргийн 4.0 хувийг эзэлж байсан бол 2018 онд 3.0, 2019 онд 2.8 хувь болж тус тус буурсан бол 2020 оны эхний 9 сард 4.3 хувь болж өссөн байна. 2017–2019 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэргийн 54.1 хувь нь Улаанбаатар хотод, 45.9 хувь нь хөдөө орон нутагт үйлдэгдсэн байна. (Тайлангийн 312 дахь хэсгийг үзнэ үү.) Прокурорын хяналтад орсон хэрэг тохиолдол болонгэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийг шийдвэрлэсэн байдлын<sup>46</sup> тухайд 2017 онд цагдаагийн байгууллагаас 519 гомдол мэдээллийг хүлээн авсан. Прокурор 124 хэрэг бүртгэлтийн хэргээс 65 эрүүгийн хэрэг үүсгэн шүүхэд шилжүүлсэн бол шүүх 155 хэргийг шийдвэрлэж, 1 хэргийг хэрэгсэхгүй болгосон. 2018 онд улсын хэмжээгээр гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 210 гэмт хэрэг бүртгэгдсэний 188 (89.5%)–д нь хэрэг бүртгэлийн хэрэг нээж, 140 (67.7%)–д нь эрүүгийн хэрэг үүсгэжээ. Энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт 2018 онд 74.5% болж өмнөх оноос 25.5 пунктээр өссөн байна. Улсын хэмжээнд 2018 онд бүртгэгдсэн 210 гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн 105 (50%) нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн нь өмнөх оноос 47 (30.9%)–гоор буурсан байна. 2019 онд прокуророос гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүний амь нас хохирсон 16 хэргийг шүүхэд шилжүүлснээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 10.1.2.8

---

<sup>46</sup> Эх сурвалж: Монгол Улс дахь цагаан ном 2016, 2017, 2018

дахь заалтад заасны дагуу Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд 2019 онд 29 хэргийг хүлээн авч, 3 хэргийг прокурорт буцааж, 2 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, 23 хэргийг хянан шийдвэрлэж, 1 хэргийн үлдэгдэлтэй байна. Ял шийтгүүлэгчдийн хувьд 22 хүнд 8-аас дээш жилийн хугацаагаар хорих ял оногдуулж, 1 хүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн байна.

333. 2020 оны хагас жилийн байдлаар Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт шийтгүүлсэн 53 хоригдол ял эдэлж байна. Хорих анги, байгууллагын хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, гэмт хэрэгт ял шийтгүүлсэн нийт 53 хоригдолд 52 удаагийн 110 цагийн хичээл сургалтыг зохион байгуулсан байна. Тэдэнд сэтгэл зүйн сургалт, хууль тогтоомжийн талаар, уур бухимдлыг зохицуулах, стресс ба түүнийг даван туулах арга зам, хандлага өөрчлөх, эерэг харилцаа бий болгох, амьдралын зөв хэвшил олгох зэрэг сэдвүүдийн хүрээнд сургалт зохион байгуулсан.

334. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогчийн нас, угсаа гарал, гэмт хэрэг үйлдэгчидтэй ямар холбоотой байсан эсэх статистик мэдээллийг 2019 оноос нарийвчлан гаргаж байна. 2019 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 985 хэргийн 207 (21.0%) нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргээр зүйлчлэгдсэн байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 2019 онд 207 бүртгэгдсэн нь өмнөх оноос 3 (1.4%)–аар буурсан байна.

335. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 207 гэмт хэргийн 186 (89.9%) нь гэр, орон сууцанд, 10 (4.8%) нь гудамж, талбайд, 6 (2.9%) нь олон нийтийн газар, 1 (0.5%) нь төрийн байгууллагад, 1 (0.5%) нь төрийн бус байгууллагад, 3 (1.4%) нь бусад газар үйлдэгдсэн өмнөх оноос гэр, орон сууцанд үйлдэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 3.0 пунктээр, бусад газарт 1.0 пунктээр буурч, харин гудамж, талбайд үйлдэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 2.9 пунктээр, олон нийтийн газарт 1.0 пунктээр өссөн байна. 2019 онд үйлдэгдсэн 207 хэргийн 112 (54.1%) хэргийг согтуугаар үйлджээ.

336. 2019 онд гэр бүлийн хүчирхийллийн 985 гэмт хэргийн улмаас 894 хүн хохирсны 850 (95.1%) нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч, 33 (3.7%) нь Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч, 8 (0.9%) нь Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч байна. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч 894 хүний 803 (89.8%) нь эмэгтэйчүүд, 66 (7.4%) нь хүүхэд байна.

337. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон 10 хүн тутмын 6 нь бие махбодын хүчирхийлэлд өртсөн 10 хүн тутмын 5 нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн эхнэр байна.<sup>47</sup>

338. 2020 оны хагас жилийн байдлаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт шийтгүүлсэн 42 хоригдол байгаа хохирогчтой ямар хамааралтай болохыг судлан үзэхэд хоригдлын эзж 1, эцэг 2, эхнэр 19, хамтран амьдрагч 8, төрсөн охин 3, дагавар хүү, охин 6, эхнэрийн дүү 1, салсан эхнэр 2 байна.

<sup>47</sup> Гэмт хэргийн статистик 2019, хуудас 8

### Хүн худалдаалахтай тэмцэх асуудал

22. Хорооноос өмнө өгсөн ажиглалт дүгнэлт (31 болон 32 дахь параграф)–н дагуу дараах мэдээллийг гаргаж өгнө үү.

22(a)–Албадан хөдөлмөр, бэлгийн мөлжлөг зэрэг хүний наймаатай холбоотой гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэхтэй холбоотойгоор тайлангийн хугацаанд тусгайлсан арга хэмжээнүүд авсан эсэх;

339. Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолоор “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх” үндэсний хөтөлбөрийг баталсан. Хөтөлбөрийн хүрээнд хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Дэд зөвлөл байгуулагдан, ажиллаж байна.

Эрүүгийн хуулийн 13.13 дугаар зүйлд албадан хөдөлмөрлүүлэхийг гэмт хэрэгт тооцсон. Бусдад хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, илт хохиролтой болзол, нөхцөл тулгаж, эсхүл хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулан эрхшээлдээ оруулж цалин хөлсгүй хөдөлмөр эрхлүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлангийн хугацаанд энэ гэмт хэргийн талаар шүүхээр хэрэг шийдвэрлэгдээгүй байна. Иргэний нийгмийн байгууллагуудаас тус гэмт хэргийг тодорхойлж байгаа элементүүд нь Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан хүн худалдаалах гэмт хэргийн тодорхойлолт дахь албадан хөдөлмөрөөс ялгах боломжгүй байгаа талаар шүүмжлэлтэй ханддаг.

Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж заасан.

340. Цагдаагийн байгууллагаас 2020 оны эхний есөн сарын байдлаар Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан хүн худалдаалах гэмт хэрэгт 15 холбогдогч, 35 хохирогчтой 12 хэрэг, Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйлд заасан бэлгийн мөлжлөг гэмт хэрэгт 12 холбогдогч, 16 хохирогчтой 9 хэрэг, Эрүүгийн хуулийн 12.6 дугаар зүйлд заасан биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэгт 17 холбогдогчтой, 51 хохирогчтой 15 хэргийг илрүүлэн холбогдох мөрдөн шалгах ажиллагааг явуулж байна. Үүний зэрэгцээ Цагдаагийн ерөнхий газрын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс, Хүйсийн тэгш эрхийн төв, Талита Ази, “Хөөрхөн зүрх” төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж гэрээний

дагуу насанд хүрээгүй хохирогч болон бэлгийн мөлжлөг, хүний наймааны хохирогч болсон иргэдийг хамгаалах байранд байрлуулж хохирогчид хууль, эрх зүйн туслалцаа үзүүлж, эргэн нийгэмшүүлэх арга хэмжээ авч ажилласан.

Цагдаагийн Ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс 2017 оны 11 дүгээр сард “Саун, караоке” хэсэгчилсэн арга хэмжээг зохион явуулж саун, массаж нэрийдлээр хүн худалдаалах, бусдыг биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг үйлдэж буй этгээдүүдийг баримтжуулан 6 газрын хууль бус үйл ажиллагааг таслан зогсоосон. Арга хэмжээний хүрээнд биеэ үнэлж байсан 20 охид, эмэгтэйчүүдийг олж тогтоон бүртгэл судалгаанд хамруулсан. Үүнээс насанд хүрээгүй 3 хүнийг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчоор тогтоож ажилласан байна.

Түүнчлэн бусдыг биеэ үнэлэхэд татан оролцуулж, орон байраар хангадаг, биеэ үнэлэхийг зохион байгуулдаг саун, массажны газрууд, зочид буудал, түрээсийн байр, ширээний охидуудаар үйлчилдэг караоке болон гудамж талбай, цахим орчимд дуудлагаар биеэ үнэлдэг охид, эмэгтэйчүүд, насанд хүрээгүй хүүхдийг бусдад зуучилдаг сэжигтэй этгээдүүдийг илрүүлж, таслан зогсоох, хариуцлага хүлээлгэх зорилгоор 8 удаагийн нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг тайлангийн хугацаанд зохион байгуулжээ. Үүний хажуугаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээ, телевиз, радиогоор цагдаагийн байгууллагын ажилтнууд сэрэмжлүүлэг мэдээлэл хүргэх ажлуудыг тогтмол хийсэн.

Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хувийн хэвшлийнхнээс санаачлан бэлтгэсэн “Бид бараа биш” сэдэвт баримтат киног бүтээхэд төрийн байгууллагаас хамтран ажилласан байна.

*22(b)-1Тайлангийн хугацаанд хууль сахиулах, цагаачлалын асуудал хариуцсан алба болон прокурорын байгууллагын албан хаагчдад аливаа тусгайлсан сургалт явуулсан эсэх,*

341. Хууль зүй, дотоод хэргийн яам нь 2017–2019 онуудад Азийн сан олон улсын байгууллагатай “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа албан хаагчдыг чадавхжуулах нь” төслийг амжилттай хэрэгжүүлж дууссан. Түүнчлэн 2017 оноос Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагатай “Монгол Улсын Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хүчин чармайлтыг бэхжүүлэх нь” төслийг хамтран хэрэгжүүлж байна.

342. Азийн сан олон улсын байгууллагатай “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа албан хаагчдыг чадавхжуулах нь” төслийн хүрээнд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий алба хаагчдыг бэлтгэх, мэргэшүүлэх цогц сургалтын хөтөлбөр боловсруулж, үндэсний сургагч багш нарыг бэлтгэсэн бөгөөд нийт 700 гаруй шүүгч, прокурор, цагдаа, хил хамгаалах болон гадаадын иргэн, харьяатын байгууллагын алба хаагчдыг сургалтад хамруулан, Дотоод хэргийн их сургуулийн 2000 орчим сонсогчийг энэ чиглэлээр сургаж тус их сургуулийн харьяа Цагдаагийн сургуульд Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх арга зүйн танхимыг байгуулсан.

343. Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран “Монгол Улсын Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хүчин чармайлтыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд 2019 онд хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, шийдвэрлэх чиглэлээр хил хамгаалах, гадаадын иргэн харьяат, цагдаа, шүүх, прокурорын байгууллагын 128 албан хаагчийг хүн худалдаалахын хохирогчдод туслалцаа үзүүлэх арга барил эзэмшүүлэх, цагдаагийн байгууллагын 25 алба хаагчийг хил дамнан хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх цагдаагийн байгууллагуудын хамтын ажиллагааг үр дүнтэй болгоход баримтлах зарчим, туршлага сэдвээр сургалтад хамруулсан.

344. Төслийн хүрээнд 2020 онд хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ хамтран хэрэгжүүлэх семинарыг цагдаа, хил, тагнуул, гадаадын иргэн, харьяат, дотоод хэргийн их сургуулийн алба хаагчид, төрийн бус байгууллагын төлөөлөл 30 хүнийг, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх, туслалцаа үзүүлэх чиглэлээр хамтарсан сургалтыг Дорноговь аймгийн Сайншанд, Замын-Үүд сумдад цагдаагийн алба хаагч, аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын нийгмийн ажилтан нийт 30 хүнийг тус тус сургасан.

345. Хууль сахиулагч болон нийгмийн ажилтнуудад зориулж хүний наймааны сэдвээр хийх сургалтыг төрөөс санхүүжүүлж эхэлсэн бөгөөд сургалтад зориулж заах багш болон сургалтын байраар хангах зэрэг тодорхой хэлбэрийн бодит дэмжлэг үзүүлсэн байна.

*22(b)-2 Эрүүгийн хуулийн зохих зүйл, заалтуудын дагуу хүний найма хийсэн гэмт этгээдүүдийг ялласан эсэх, прокурорын хяналтад оруулсан эсэхийг нягтлах талаар хүчин чармайлт гаргасан эсэх;*

346. Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд хүн худалдаалах гэмт хэргийг насанд хүрсэн хүний эсрэг үйлдсэн бол хоёроос найман жилийн хорих ял, хүүхдийн эсрэг үйлдсэн бол таваас арван хоёр жил хүртэлх хугацаагаар хорих ял оноохоор заасан. Эдгээр ял шийтгэл нь хангалттай чанга бөгөөд бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийн ял нь хүчин гэх мэт бусад хүнд гэмт хэрэгт оноодог ялтай дүйцэхүйц хүнд заалт болсон. Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйлээр бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах зарим хэлбэрүүдийг тусгаж хуульчилсан.

347. Эрүүгийн хуулийн 13.1, 12.3 дугаар зүйлийн дагуу мөрдөн шалгаж байсан 26 хэргийг прокурор хэрэгсэхгүй болгосон. Улсын Ерөнхий прокурорын газраас 2018 оны эхээр хэрэгсэхгүй болгосон дээрх хэргүүдийг дахин шалгаж, албан ёсоор мөрдөх ажлын хэсэг байгуулсан.

348. 2018 онд хүний худалдаалах, бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах зэрэг 62 этгээдийг буруутган мөрдөн шалгаснаас 21 хэрэгт нь ял шийтгэл оногдуулсан. Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан хүн худалдаалах гэмт хэргийн дагуу 15 гэмт хэрэг, Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйлд заасан бэлгийн мөлжлөг гэмт хэргийн дагуу 6 яллагдагч байсан. Шүүхээс 2019 онд Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан хүн худалдаалах 7 хүнд холбогдох 2 хэргийг хянан шийдвэрлэж, тус тус ял, эрүүгийн хариуцлага оногдуулсан байна.

*22(с)–Тайлангийн хугацаанд хүний наймааны хохирогчдын тэр дундаа насанд хүрээгүй хүний хохирлыг барагдуулсан байдал, хохирогчдыг хамгаалах талаар тухайлбал хамгаалах байр хангалттай эсэх, хүний наймааны хэрэг тохиолдлыг цагдаагийн байгууллагад мэдээлэхэд туслалцаа үзүүлсэн эсэх зэрэг хохирогчийг хамгаалах тусгайлсан арга хэмжээ авсан эсэх;*

349. Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйлд заасан бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийг 14–өөс дээш насны хүний эсрэг үйлдсэн бол хоёроос найман жилийн хорих ял, 14–өөс доош насны хүүхдийн эсрэг үйлдсэн бол арван хоёроос хорин жил хүртэлх хугацаагаар хорих ял оноохоор заасан.

350. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах чиглэлээр төрөөс онцгой анхаарч, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгаалах үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагуудад Хууль зүй, дотоод хэргийн сайдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас санхүүжүүлж байна. 2018 оноос хойш жил бүр нээлттэй сонгон шалгаруулалт явуулж, сонгогдсон нэг төрийн бус байгууллагад 30 сая төгрөг (10.623 ам.доллар)–н санхүүжилтийг олгож байна.

351. Улсын хэмжээнд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх 4 байр ажиллаж байна. Үүнээс цагдаагийн байгууллагын гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн дор 1, “Хүйсийн тэгш эрхийн төв” төрийн бус байгууллагын харьяа 2, “Талита ази” төрийн бус байгууллагын харьяа 1 түр хамгаалах байр байна.

352. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 2018 оноос эхлэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгаалах үйлчилгээ үзүүлэх зөвлөх үйлчилгээний нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан байгууллагатай хамтран ажиллаж, энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд жил бүр 20 сая төгрөг төсөвлөн санхүүжүүлдэг.

353. Улсын хэмжээгээр 2018 онд хүн худалдаалах гэмт хэрэг 10 бүртгэгдсэн нь хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэргийн 8.7%–ийг эзэлж байна. Хүн худалдаалах 10 гэмт хэргийн 7 (70.0%) нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг насны ангиллаар авч үзвэл ихэвчлэн 14–өөс 29 насныхан байна.

*22(d)–Хүний наймаа хийсэн гэмт этгээдүүдийг мөрдөн шалгасан, ялласан, ял шийтгэл ногдуулсан тоо, хохирогчдын хохирлыг барагдуулах зохицуулалт бүхий заалтууд.*

354. (Тайлангийн 346–348 дахь хэсгийг үзнэ үү.) Эцэг эх, хууль ёсны асран хамгаалагчгүйгээр хилээр гарч буй монгол хүүхдийг хүний наймаанд өртөж буй эсэхийг шалгах шинэ програм хангамжийг Гадаадын иргэн харьяатын газарт суурилуулж, хэрэглээнд оруулсан. Ийнхүү суурилуулснаас хойш нийт 167 хүүхдэд шалгалт хийсэн. Хэдийгээр эдгээр хүүхдүүдийн дунд хүний наймааны хохирогч илрээгүй ч, хил гаалийн ажилтнууд тэдний паспортанд яаралтай тусламж шаардлагатай үед хэрэглэх консулын

холбоо барих мэдээлэл бүхий хуудсыг хавчуулж, үргэлжлүүлэн хянах зорилгоор биометрийн хувийн өгөгдлийг хууль сахиулах байгууллагуудад илгээж хэвшээд байна.

355. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу хохирогч нь “эд хөрөнгө, нэр төр, алдар хүнд, сэтгэл санааны хохирлын” нөхөн төлбөрийг гэм буруутай этгээдээс шаардах эрхтэй. Одоогийн байдлаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын хувьд энэ хуулийн зүйл заалтаар эд хөрөнгө, нэр төр, алдар хүнд, сэтгэл санааны хохирлын нөхөн гаргуулсан тохиолдол гараагүй байна.

356. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн<sup>48</sup> 5 дугаар зүйлийн 5.3.17–д хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн тухай заасан. Тус сангийн дүрмийг Засгийн газрын 2018 оны 179 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан. Тус дүрмийн 2.1–д зааснаар сангийн хөрөнгө нь улсын төсвийн хөрөнгө болон гадаад улс, олон улсын байгууллага болон гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс өгсөн буцалтгүй тусламж, хандиваас бүрдэнэ. Тус сангийн хөрөнгөөр 2017 онд 7 иргэнийг хилийн чанадаас буцаан авчирч байсан. 2018 онд эрх бүхий байгууллагууд хүн худалдаалах гэмт хэргийн 2 хохирогчийг Малайз улсаас, Хятад улсаас 17 хохирогчийг, Камбож улсаас 1 хохирогчийг нийт 20 иргэнийг эх оронд нь буцаан авчирсан.

357. 2020 онд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, Гадаад хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн алба, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, “Хүйсийн тэгш эрхийн төв” төрийн бус байгууллага хамтран Малайз улс, Тайландын Хаант улсад хүний наймааны хохирогч болсон байж болзошгүй Монгол улсын 7 иргэнийг тусгай үүргийн нислэгээр эргүүлэн авчирсан. Цагдаагийн байгууллагаас дээрх 7 хохирогчоос хэргийн шалтгаан нөхцөлийг тодруулан хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

### **Хүүхдэд бие махбодид шийтгэл үзүүлэхийн эсрэг**

*23.Хорооноос өмнө өгсөн ажиглалт дүгнэлт (25 болон 26 дахь параграф)–н дагуу дараах мэдээллийг гаргаж өгнө үү.*

*23(а)–Хүүхдийн бие махбодид бүх хэлбэрээр гэмтэл учруулж шийтгэхийг хориглохыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхтэй холбоотой тусгай арга хэмжээ авах, бие махбодид гэмтэл учруулж шийтгэсэн гэж мэдээлэгдсэн бүх хэрэг тохиолдлыг мөрдөн шалгах, яллах, ял шийтгэл ногдуулах;*

358. 2017 оноос эхлэн гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг, хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах тогтолцоог бэхжүүлэхэд анхаарч тодорхой арга хэмжээг хэрэгжүүлээд байна. Тухайлбал: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэд хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээ үзүүлэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх түр хамгаалах байр ажиллуулах, Засгийн газрын шийдвэрээр Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудлаар сургалт, судалгаа, мэдээллийн бие даасан төвийг байгуулан

---

<sup>48</sup> <https://www.legalinfo.mn/law/details/14848?lawid=14848>

ажиллуулж байна.

359. Хүүхдийн эрхийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах үүднээс хүүхдийн эрхийг хөндсөн зөрчлийг шалган шийдвэрлэх чиг үүрэг бүхий албан хаагчдыг мэргэшүүлж, хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрх олгон, ажиллуулж байна. 2017 онд 26 зөрчил, 2018 онд 299 зөрчил, 2019 оны байдлаар зөрчлийн 72 дуудлага, мэдээлэл хүлээн авч, 36 иргэнд зөрчлийн хэрэг үүсгэн, холбогдох торгууль шийтгэврийг оногдуулсан байна.

360. Гэмт хэргийн талаарх статистик мэдээллээр 2018, 2019 онуудад гэмт хэргийн улмаас нас барсан 10 хүн тутмын 1 нь 18 хүртэлх насны хүүхэд байна.

*23(b)–Бие махбодийн шийтгэлийн хор уршгийн талаарх мэдлэгийг дээшлүүлэхийн тулд олон нийтийн болон мэргэжлийн хүмүүст зориулсан аливаа кампанит ажил хийгдсэн эсэх, мөн боловсрол олгохдоо эерэг хандлагатай, хүчирхийллийн бус арга хэрэглэхийг дэмжих, хүүхдэд анхаарал тавих, хүүхдийг анхаарлын төвд байлгахыг дэмжих*

361. Хүүхдийн бие махбодид бүх хэлбэрээр гэмтэл учруулж шийтгэхийг хориглохыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх үүднээс хүүхэд гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй эмзэг цэгүүдийг иргэд, олон нийтийн оролцоотой хяналтад авах зорилгоор “Хүүхэд хамгаалагч” төслийг боловсруулсан. Тус төслийн санхүүжилтийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/116 дугаар тушаалаар шийдвэрлэсэн. “Хүүхэд хамгаалагч” ахмадуудтай гэрээ байгуулж, улсын хэмжээнд 05 дугаар сарын 01–ний өдрөөс эхлэн, нийт 194 ахмад ажилтныг урамшуулалтайгаар ажиллуулж байна.

362. Цахим орчин дахь зохистой хэрэглээг бий болгох, хүүхдийг цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг, түүний дотор хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “UNFRIEND” тусгай арга хэмжээг 2018 онд зохион байгуулсан. Уг ажлын хүрээнд урьдчилан сэргийлэх агуулга бүхий 55 постер, 15 видео сурталчилгаа болон нэвтрүүлэг, мөн 1 дуу бүтээж, нийт 31 телевиз, олон нийтийн цахим сүлжээгээр түгээсэн нь давхардсан тоогоор 6101000 хүнд хүрсэн байна.

363. Тусгай арга хэмжээний үеэр олон нийтийн сүлжээн дэх садар самуун сурталчилсан болон хууль бус агуулга бүхий контент агуулсан групп, пэйж хуудаснуудын мэдээллийг хүлээн авах “Хар жагсаалт” группыг үүсгэн 19,300 гишүүнийг элсүүлэн ажилласны зэрэгцээ хууль бус үйл ажиллагаа явуулсан 32 нийгмийн сүлжээний хуудас, группыг илрүүлж, Фэйсбүүк компанид мэдэгдэн устгуулах арга хэмжээ авсан.

364. Хүүхэд, залуусыг цахим орчин дахь гэмт хэрэг, зөрчил, эрсдэлт хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, нийгмийн сүлжээний зүй зохистой хэрэглээг бий болгох, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор “ЗӨВИЙГ ТҮГЭЭЭ” нэгдсэн арга хэмжээг 2019 онд зохион байгуулсан.

365. Хүүхэд хамгааллын үйлчилгээнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрт 2017 онд 1.2 тэрбум төгрөг, 2018 онд 6.4 тэрбум төгрөг, 2019 онд 7,6тэрбум, 2020 онд 8 тэрбум төгрөгийг төсөвлөн баталсан. Хүүхдийн хөгжил, хамгаалалд улсаас зарцуулах төсөв 2017 онтой харьцуулахад 2020 онд дунджаар 3 дахин нэмэгдсэн байна.



366. Хүүхэд хамгааллын тухай хууль болон “Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журам”-ын дагуу хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудыг магадлан итгэмжилж эхэлсэн. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжилснээр төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх боломжтой болсон.

367. 2018 онд 6 сарын хугацаатай магадлан итгэмжлэл авсан 42 төрийн бус байгууллага авснаас 18 төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж, хамгааллын үйлчилгээ шаардлагатай байгаа 1066 хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж, 380,0 орчим сая төгрөгийн санхүүжилт олгосон. 2019 онд 2 жилийн хугацаатай магадлан итгэмжлэл 39 төрийн бус байгууллага авснаас “Хүчирхийллийн эсрэг үндэсний төв”, “Хүүхдийн эрх, хамгаалал төв” төрийн бус байгууллага, “Монголын урлагийн сэтгэл заслын мэргэжлийн холбоо” гэсэн 3 төрийн бус байгууллагатай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж, 140,6 сая төгрөг(? ам.доллар)-н санхүүжилт олгосон. 2020 онд 2 жилийн хугацаатай 8 төрийн бус байгууллага магадлан итгэмжлэл авсан.

368. Хүүхдийн эрхийн улсын байцаагчид 38 төрлийн зөрчлийг шалган шийдвэрлэж байна. Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйл, 10.23 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу 2017 онд 26, 2018 онд 126, 2019 онд 171, 2020 оны хагас жилийн байдлаар 43 зөрчил шалган шийдвэрлэсэн.

369. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ түр хамгаалах байранд 2017 онд 0–18 хүртэлх насны 321, 2018 онд 945, 2019 онд 996, 2020 оны 9 сарын байдлаар 718 хүүхдийг түр хамгаалан байршуулж хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн.

370. Хууль зөрчсөн, гэмт хэргийн гэрч, хохирогч болсон хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх чиг үүрэгтэй салбар дундын Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог аймаг, дүүрэг бүрт байгуулсан. 2017 онд 618 хүүхдэд, 2018 онд 897, 2019 онд 902, 2020 оны 2 дугаар улирлын байдлаар 329 хүүхэд хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлсэн байна.

371. Хүүхдийг аливаа хүчирхийллээс хамгаалах урьдчилан сэргийлэхэд эцэг, эхийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, салбар дундын зохицуулалт болон хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Засгийн газраас 2019–2020 оныг “Хүүхдийн хөгжил хамгааллын жил” болгон зарлаж, салбар дундын төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангаж байна.

### **Лесбиан, гей, бисексуал, трансжэндэр болон интерсекс хүмүүсийн эсрэг хүчирхийлэл ба ялгаварлан гадуурхалт**

*24.Бэлгийн цөөнхийн талаар авч буй арга хэмжээнүүдийн тухай мэдээлэл өгнө үү.*

*24–1.Бэлгийн цөөнх болох лесбиан, гэй, бисексуал, трансжендер, интерсекс зэрэг хүмүүс хүчирхийлэлд өртөх, ялгаварлан гадуурхагдахаас урьдчилан сэргийлэх талаар авч буй арга хэмжээнүүдийн талаар шинэчилсэн мэдээлэл ирүүлнэ үү.*

372. Эрүүгийн хуулиар бэлгийн болон хүйсийн чиг баримжаагаар ялгаварлан гадуурхах үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор тусгасан. Тус хуулийн Арван дөрөвдүгээр бүлэг буюу Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэгт хамаарах 14.1 дүгээр

зүйлд ялгаварлан гадуурхах гэмт хэргийг хуульчилсан.

373. Лесбиан, гей, бисексуал, трансжэндэр (цаашид “ЛГБТ”) хүмүүсийн эрхийг хамгаалах НҮБ-ын “Free and equal campaign”-ыг Монгол Улсад албан ёсоор эхлүүлэх, ЛГБТ хүмүүсийн эрхийг хүндэтгэх, хамгаалах асуудлаар олон нийтийн дунд мэдээлэл, ухуулга сурталчилгаа хийж, шүүх, прокурорын байгууллагын ажилтнуудад сургалт зохион байгуулах ажлыг НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх UPR Trust Fund-ын төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр болсон.

374. ЛГБТ иргэд ямар ч тохиолдолд өөрийгөө аль болохоор нууцалдаг учир гомдол мэдээлэл нь цагдаагийн байгууллагад анх бүртгэгдэхдээ ЛГБТ хүмүүсийн бэлгийн болон хүйсийн баримжаанаас шалтгаалсан гэж бүртгэгдээгүй агсам тавьсан, зодолдсон гэх дуудлага мэдээллээр бүртгэгдэн шалгагдсан байна. Тайлангийн хугацаанд Цагдаагийн байгууллагад хандсан 6 тохиолдлоос эрүүгийн хэрэг үүсгэсэн 3, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан 3 гомдол байна.

375. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн богино хугацааны сургалтуудад бэлгийн чиг баримжаа хүйсийн баримжааны илэрхийлэл, ялгаварлан гадуурхалт, гутаан доромжлохын эсрэг агуулга оруулсан.

*24–2.Эдгээр хүмүүс болон хамгаалалт шаардлагатай байгаа нийгмийн эмзэг бүлгийнхэн тэр дундаа ДОХ-той хүмүүст зориулсан хамгаалалт хангалттай эсэхийг нягтлах, бие махбодийн төдийгүй хүнлэг бус аливаа хүчирхийллээс хамгаалах цогц эрх зүйн орчин бий болгох талаар авсан арга хэмжээний талаар мэдээлэл өгнө үү.*

376. ХДХВ, ДОХ-той хүнд болон түүний эхнэр, нөхөр, гэрлэлтээ бүртгүүлээгүй боловч хамтын амьдралтай байгаа хүн, эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчид зөвлөгөө өгөх, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журмыг Эрүүл мэндийн сайдын 2017 оны 305 дугаар тушаалаар батласан.

377. Эрүүл мэндийн сайдын 2009 оны 241 дүгээр тушаалаар халдварт өвчтэй жирэмсэн эмэгтэй амаржих тасагт үйлчлүүлэх өвчний заалтын 6 дахь заалтад ХДХВ/ДОХ-той жирэмсэн эхийг харьяалал харгалзахгүй Халдварт өвчин судлалын үндэсний төвд төрүүлэхээр заасан байсныг Эрүүл мэндийн сайдын 2017 оны 305 дугаар тушаалаар “БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тусламж үйлчилгээ үзүүлэх журам”-д өөрчлөн зохицуулж мэргэжлийн тусламж үйлчилгээг харьяаллын дагуу үзүүлэхээр болсон.

378. БЗДХ, ХДХВ-ын тусламж үйлчилгээ үзүүлэх журамд аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Нийгмийн эрүүл мэндийн төв нь эрсдэлт бүлгийн хүн амд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлж ажиллана гэж заасан.

379. ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ үйлчилгээний төв нь аймгийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, тусгай эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн төв, сумын эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагын бүрэлдэхүүнд багтаж үйл ажиллагаа явуулах ба тухайн эрүүл мэндийн байгууллагын удирдлага нь зөвлөгчийг томилж, төсөв орон тоондоо

тусган ажиллуулна.

380. Эрсдэлт бүлгийн олон нийтийг түшиглэн эрсдэлт бүлгийн олон нийт, хүрч очих ажилтнуудыг ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ үйлчилгээний зөвлөгч бэлтгэх сургалтанд хамруулсны дараа ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээг арьсны бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй аргыг сонгон хийнэ. Хувь хүний хүсэлтээр боломжит цагт төлбөртэй үйлчилгээ авах эсхүл эмч, сувилагч гэрээр очиж эрсдэлт бүлгийнхэнд зориулсан тусгай үйлчилгээ үзүүлэх боломжтой болсон. Энэ тохиолдолд ХДХВ-ийн халдвар илрүүлэх түргэвчилсэн аргуудыг хэрэглэж байна.

381. ХДХВ-тай өвчтөнд хөнгөвчлөх болон эмнэлгийн тусламж үйлчилгээг ээлтэй чанартай үзүүлэх зорилгоор Глобал сангийн санхүүжилтээр ХӨСҮТ-д 4 ортой сүүлийн үеийн тоноглол бүхий тасаг байгуулж эмч эмнэлгийн мэргэжилтнийг сургасан.

382. Монгол дахь Канад Улсын Элчин сайдын яамны санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Улаанбаатар хот дахь эрсдэлт бүлгийн хүн ам болох эмэгтэй биеэ үнэлэгчид, эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд болон ХДХВ-тай амьдарч буй хүмүүст үзүүлэх бэлгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах нь” сэдэвт төслийн хүрээнд ХДХВ-тай хүмүүс болон түүний ар гэр, хамтран амьдрагчид ганцаарчилсан болон хосын зөвлөгөө өгөх үйлчлүүлэгчийн нууцыг хадгалсан бүлгийн ярилцлагын өрөө байгуулан тохижуулсан.

*24-3. Аливаа хүчирхийллийн талаар өгсөн гомдол мэдээлэл цагдаагийн байгууллагад бүртгэгдэж, мөрдөн шалгагддаг эсэхийг нягтлах гомдол шалган шийдвэрлэх механизм болон түүнд холбогдох бодлогын болон хэрэгжилтийн талаарх мэдээллийг гаргаж ирүүлнэ үү.*

383. ЛГБТ иргэдтэй холбоотой, биеэ үнэлсэн, гудамж талбай, олон нийтийн газар танхайрсан зөрчлүүд цагдаагийн байгууллагад бүртгэгдэж хуулийн дагуу шалгаж шийдвэрлэсэн.

384. Тайлангийн хугацаанд цагдаагийн байгууллагад хандсан 6 тохиолдлоос эрүүгийн хэрэг үүсгэсэн 3, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан 3 тохиолдол байна.

385. ЛГБТ иргэд ямар ч тохиолдолд өөрийгөө аль болохоор нууцалдаг учир гомдол мэдээлэл нь цагдаагийн байгууллагад анх бүртгэгдэхдээ ЛГБТ хүмүүсийн бэлгийн болон хүйсийн баримжаанаас шалтгаалсан гэж бүртгэгдээгүй агсам тавьсан зодолдсон гэх дуудлага мэдээллээр бүртгэгдэн шалгагдсан байна.

*24-4. Бэлгийн болон хүйсийн чиг баримжаанд тулгуурлан нийгмийн тодорхой бүлгийн эмзэг хэсэгт орох хүмүүсийн эсрэг хүчирхийлэл үйлдэгчдийг тогтоох талаар авч буй арга хэмжээнүүдийн тухай мэдээлэл өгнө үү.*

386. Цагдаагийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэгт “Цагдаагийн байгууллага дараах тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сүлжээ, сан үүсгэн үйл ажиллагаандаа ашиглана”, 61.6 дахь хэсэгт “Мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, шалгах, үнэлэн шинжлэх, ашиглах, шилжүүлэх, хүлээн авах, хуваарилах, үр дүнг тооцох, лавлагаа өгөх журмыг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”

гэж тус тус заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/195 дугаар тушаалаар баталсан "Мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, шалгах, үнэлэн шинжлэх, ашиглах, шилжүүлэх, хүлээн авах, хуваарилах, үр дүнг тооцох, лавлагаа өгөх журам" – ыг үйл ажиллагаандаа мөрдөж байна. Тус журмын хүрээнд ЛГБТ хүмүүсийн эсрэг үйлдэгдсэн зөрчил, гэмт хэргийн талаарх мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх боломжийг судалж байна.

387. Цагдаагийн ерөнхий газраас гэмт хэрэг, зөрчлийг шалгах явцын талаарх мэдээллийн нэгдсэн сан, тайлан мэдээний програмд шинэчлэл хийх, мэдээллийн сангуудын лавлах гаргах, иргэний мэдээллийг нэгдсэн стандартад оруулж, бүртгэлжүүлсэн сан үүсгэхээр төлөвлөөд байна. Шинээр бүрдүүлэх мэдээллийн сангийн жагсаалтад ЛГБТ хүмүүсийг ялгаварлан гадуурхсан тухай гомдлыг бүртгэх бүртгэл багтсан бөгөөд уг мэдээллийн санг ашиглан бэлгийн болон хүйсийн чиг баримжаагаар ялгаварлан гадуурхахтай тэмцэх ажилд ашиглахаар төлөвлөн ажиллаж байна.

*24–5 Шинээр батлагдсан Эрүүгийн хуульд бэлгийн цөөнх болох лесбиан, гэй, бисексуал, трансжендер, интерсекс зэрэг хүмүүсийн талаар аливаа зохицуулалт, заалт уг хуульд тусгагдсан эсэхийг мэдээлнэ үү*

388. 2015 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Гэмт хэрэгт тооцох, ял оногдуулахад хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй байдлаар ялгаварлан гадуурхахгүй" гэж заасан.

389. Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлд хүний алах гэмт хэргийг хуульчилсан. Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2.14 дэх хэсэгт "үзэл бодол, арьсны өнгө, үндэс, угсаа, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаагаар нь үзэн ядаж алсан бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэнэ" гэж, 12.1 дүгээр зүйлд хүчиндэх гэмт хэргийг, 12.2 дугаар зүйлд бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн тайлбар хэсэгт "хүчиндэх болон бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн хохирогч нь бэлгийн халдашгүй байдал нь зөрчигдсөн аль ч хүйсийн хүн байж болно" гэж тус тус заасан нь бэлгийн цөөнхийн эрх ашгийг хамгаалсан зохицуулалт болсон.

390. Эрүүгийн хуулийн 14.1 дүгээр зүйлд заасны дагуу хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

## Бусад асуудал

25. Хорооноос өмнө өгсөн ажиглалт дүгнэлт (42 дахь параграф<sup>49</sup>)–н дагуу Хорооны зүгээс мэдээллийг хүлээн авч, хэлэлцэх эрх хэмжээг хүлээн зөвшөөрч буй эсэх талаар Конвенцийн 21 болон 22 дугаар зүйлд заасан мэдэгдлийг Оролцогч Улс хийх асуудлаар аливаа нэг бодлого бий эсэх, уг асуудлыг эргэцүүлэн авч үзэж буй эсэх тухай мэдээллийг гаргаж өгнө үү.

391. Тайлангийн хугацаанд энэ асуудлаар тодорхой бодлогын шийдвэр гаргаагүй болно.

26. Оролцогч Улс нь терроризмын аюул заналхийллийн эсрэг авч буй хариу арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар тайлбар өгнө үү.

26–1 Оролцогч Улс нь терроризмын аюул заналхийллийн эсрэг ямар хариу арга хэмжээг авч буй эсэх талаар мэдээлэл өгнө үү. Эдгээр арга хэмжээнүүд хуулиар баталгаажсан хүний эрхүүдэд сөргөөр нөлөөлж буй эсэх талаар тайлбар өгнө үү. Хэрэв нөлөөлөл үзүүлж байгаа гэж үзэж байвал хүний эрхэд хэрхэн нөлөө үзүүлж байна вэ?

392. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх хуулийн 6 дугаар зүйлд зааснаар төрөөс зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх талаар терроризмын нөхцөл байдал, түүний суурь нөхцөлийг үнэлэх, зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, терроризмын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж, терроризмоос ангид байх үзлийг төлөвшүүлэх, терроризм үл нутагших, террорист этгээд нэвтрэхгүй, орогнохгүй байх орчин нөхцөлийг бүрдүүлэх, мөн террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны бэлэн байдлыг хангах, хүн, хуулийн этгээд, улсын онц чухал объект, хүн ам олноор төвлөрсөн газрыг террорист үйлдлээс сэргийлэн хамгаалах, террорист үйлдэлд өртөх эрсдэлийг бууруулах, түүнээс үүсэх хохирол, хор уршгийг багасгахад чиглэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, зэвсэг, бодис, хэрэгсэл, юмсыг террорист үйлдэлд ашиглахаас сэргийлэх, зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх чиглэлээр олон улсын болон гадаад, дотоодын байгууллагатай хамтран ажиллах, зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэхэд хүн, хуулийн этгээд, хэвлэл мэдээллийн болон бусад байгууллагын оролцоог нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

393. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1–д заасны дагуу терроризмын нөхцөл байдлыг үнэлэхдээ бүс нутаг, улс оронд үйлдэгдсэн, үйлдэгдэж болзошгүй терроризм, түүний чиг хандлага, арга

---

<sup>49</sup> Хороо зөвлөмжөө дахин давтан (CAT/C/MNG/CO/ 1, 29 дүгээр зүйлийг харна уу), Оролцогч улс нь Хүний эрхийн төлөв байдлын дагуу Конвенцийн 21, 22 дугаар зүйлд заасан хүлээн зөвшөөрсөн олон талт үе шаттай хэлэлцэн тохиролцсон тунхаглал гаргах;  
CAT/C/MNG/CO/ 1, 29 дүгээр зүйл – The Committee recommends that the State party consider making the declarations envisaged under articles 21 and 22 of the Convention.

хэлбэр, аюул занал, эрсдэлд дүн шинжилгээ хийж, олон улсын байгууллагын зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх бодлого, үйл ажиллагааг харгалзан дүгнэлт гаргана.

*26–2 Түүнчлэн энэ чиглэлээр хууль сахиулах байгууллагуудын албан хаагчдад ямар сургалт явуулсан талаар тодорхойлно уу.*

394. Терроризмтой тэмцэх зөвлөлийн ажлын албанаас төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийг оролцуулсан сургалт мэдээллийн ажлыг тасралтгүй зохион байгуулж тайлангийн хугацаанд терроризмтой тэмцэх бодлогын талаар нийт 15000 (арван таван мянга) орчим иргэд, хууль сахиулах байгууллагын албан хаагчдад мэдээлэл өгсөн. Тухайлбал: Хаан шонхор, Цагаан шонхор зэрэг сөрөг тусгай ажиллагааны дадлага сургуулилтад хууль сахиулах байгууллагын албан хаагчдыг хамруулсан.

*26–3. Терроризмтой тэмцэх бодлогын хүрээнд батлагдсан хууль тогтоомжийн дагуу ял шийтгэл хүлээлгэсэн хүний тоо;*

395. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид терроризмтой холбоотой гэмт хэргийг зүйлчилсэн. Тухайлбал 20.2 дугаар зүйлд террорист үйл ажиллагаанд уриалах, түүнийг нийтийн өмнө зөвтгөх, хатгах гэмт хэргийг, 29.10 дугаар зүйлд терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг, 29.11 дугаар зүйлд үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх гэмт хэргийг тус тус хуульчилсан.

396. Эрүүгийн хуулийн 20.2 дугаар зүйлд террорист үйл ажиллагаанд уриалах, түүнийг нийтийн өмнө зөвтгөх, хатгах гэмт хэргийг заасан. Террорист суртал ухуулга явуулсан, эсхүл түүнийг дэлгэрүүлсэн, эсхүл террорист үйл ажиллагаа явуулахыг уриалсан, эсхүл олон нийтийн өмнө зөвтгөсөн, эсхүл бусад этгээдийг хатгасан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Энэ гэмт хэргийг төрийн албан хаагч үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

397. Эрүүгийн хуулийн 29.10 дугаар зүйлд терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг хуульчилсан. Террорист этгээд, террорист үйлдэл, үйл ажиллагаанд зарцуулагдахыг урьдчилан мэдсээр байж шууд болон шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, өөрчилсөн, шилжүүлсэн, зарцуулсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Энэ гэмт хэргийг хориг арга хэмжээг зөрчиж үйлдсэн бол найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

398. Эрүүгийн хуулийн 29.10 дугаар зүйлд заасан терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг хориг арга хэмжээг зөрчиж хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг албадан татан буулгана. Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

399. Эрүүгийн хуулийн 29.11 дугаар зүйлд үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх гэмт хэргийг хуульчилсан. Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон

хими, биологийн, эсхүл үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсэг, тэдгээрийн түүхий эд, эд зүйл, тоног төхөөрөмж, технологийг боловсруулах, үйлдвэрлэх, хуримтлуулах, олж авах, худалдах үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд, эсхүл шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, өөрчилсөн, шилжүүлсэн, зарцуулсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, хуулийн этгээдийг албадан татан буулгана.

400. Тайлангийн хугацаанд Эрүүгийн хуулийн дээрх зүйлээр зүйлчлэгдэж, ял шийтгэл хүлээлгэсэн тохиолдол бүртгэгдээгүй болно.

*26–4. Олон улсын эрх зүйн дагуу хүлээсэн тэр дундаа тус Конвенцийн дагуу хүлээсэн үүрэгт дээрх арга хэмжээнүүд хир нийцэж буйг Оролцогч Улс хэрхэн нягталсан талаар мөн тайлбарлана уу*

401. 2006 онд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг анх баталсан. Тус хуулийг 2013 онд шинэчлэн батласан. Шинэчлэгдэн батлагдсан тус хуульд орсон өөрчлөлтүүд нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд гарч байсан дутагдал, сул талуудыг засч, залруулахад чиглэгдсэн.

402. Терроризмтой тэмцэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх” хуулийг 2019 оны 10 дугаар сарын 10–ны өдөр батлагдсан.

403. Санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны журмыг 2019 оны 01 дүгээр сарын 31–ний өдрийн Засгийн газрын 54 дүгээр тогтоолоор баталсан. Тус тогтоолыг шинэчлэн боловсруулж, 2019 оны Засгийн газрын 464 тоот тогтоолоор Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журмыг баталсан.

404. Засгийн газрын 2019 оны 460 дугаар тогтоолоор Терроризмтэй тэмцэх зөвлөлийн ажиллах журам, ажлын албаны бүтцийг баталсан. Зөвлөлийг Тагнуулын ерөнхий газрын дарга ахалдаг. Терроризмтой тэмцэх зөвлөл нь Монгол Улсын хэмжээнд зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх үндэсний чадавхыг бэхжүүлэх, эрх зүй, зохион байгуулалтын тогтолцоог сайжруулах, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, мэдээлэл солилцооны шуурхай байдлыг хангах замаар терроризм үл нутагших нөхцөлийг бүрдүүлэх чиг үүрэгтэй.

405. Терроризмтой тэмцэх зөвлөлийнүйл ажиллагаа зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмоос урьдчилан сэргийлэх чиглэлд түлхүү төвлөрч байна. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл нь терроризмын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж, терроризмоос ангид байх үзлийг төлөвшүүлэх, терроризмын нөхцөл байдал, түүний суурь нөхцөлийг үнэлэх замаар холбогдох үнэлгээ, дүгнэлт хийж түүнийг Ерөнхий сайд болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулах, терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагыг шуурхай мэдээллээр хангах юм.

Үүний дагуу терроризмтой тэмцэх чиглэлээр Монгол Улсын хийж хэрэгжүүлэх богино болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөг (2020–2024) боловсруулж, батлуулсан.

406. Тайлангийн хугацаанд 2019 оны 06 дугаар сарын 02–ны өдөр “Терроризмтой тэмцэх салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”, 2019 оны 09 дүгээр сарын 03–ны өдөр “Терроризмтой тэмцэхэд хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн хоорондын хэлэлцээр”, 2019 оны 10 дугаар сарын 10–ны өдөр “Терроризмтой тэмцэх салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Киргиз Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг тус тус байгуулсан.

407. 2018 онд Монгол Улсын терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх эрсдэлийн үнэлгээг анх удаа боловсруулсан. 2019 онд Нэгдсэн Үндэстний Байгууллага, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагатай хамтран “Хүчирхийлэл дагуулсан экстремизм, радикалчлалтай тэмцэхэд бүх нийгмийг хандуулах нь” сэдэвт өндөр түвшний олон улсын бага хурлыг Улаанбаатар хотноо зохион байгуулж, Улаанбаатарын тунхаглал баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлж байна.

*26–5 Терроризмтой тэмцэх чиглэлийн ажил хариуцаж буй хүмүүст чиглэгдсэн хамгаалах хууль зүйн арга хэрэгсэл, баталгааг хуульд тусгасан байдал, бодит байдалд хэрхэн хэрэглэж буй байдал; терроризмтой тэмцэх арга хэмжээг хэрэглэхэд олон улсын стандартуудыг үл хайхарч байгаа талаар гомдол гарч байсан эсэх; хэрэв ийм гомдол гарч байсан бол түүний үр дүн юу болсон зэргийн талаар тайлбар өгнө үү.*

408. Терроризмтой тэмцэх чиглэлийн ажил хариуцаж буй хүмүүст чиглэгдсэн хамгаалах хууль зүйн арга хэрэгсэл, баталгааг хангасан эрх зүйн зохицуулалтыг хуулинд дараах байдлаар тусгасан. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх терроризмтой тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлд террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох алба хаагчийн нийгэм, эдийн засаг, хууль зүйн баталгааг тусгайлан зохицуулсан. Тухайлбал: Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцохоор томилогдсон зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тусгай бэлтгэл, зориулалт бүхий нэгжийн алба хаагчийг гэнэтийн осол, амь насны даатгалд заавал хамруулж, холбогдох зардлыг төр хариуцна.

409. Засгийн газар террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох тусгай бэлтгэл, зориулалт бүхий нэгжийн алба хаагчийн галт зэвсэг, тусгай хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж болон бусад эдийн хангалтыг хариуцна.

410. Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцсоны улмаас гэмтсэн, эрүүл мэндэд нь хохирол учирсан бол эмчилгээний зардал, хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд тэтгэмж, үндсэн цалингийн зөрүү болон хиймэл эрхтэн хийлгэх, амрах, нөхөн сэргээхтэй холбогдох зардлыг төр хариуцна.

411. Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны үед үүрэг гүйцэтгэсэн алба хаагчид олгох албан томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж



олгоно. Түүнчлэн террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны нэгжид ажилласан алба хаагчийн ажилласан нэг жилийг нэг жил дөрвөн сартай дүйцүүлэн тооцно.

412. Терроризмтой тэмцэх арга хэмжээг хэрэглэхэд олон улсын стандартуудыг үл хайхарч байгаа талаар, терроризмтой тэмцэх хууль тогтоомж түүнийг даган гарсан дүрэм, журамтай холбоотой иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол гарч байгаагүй болно.

### III. ХОРООНООС ШААРДСАН НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

*27. Хорооны зөвлөмж, Конвенцийн зүйл, заалтуудыг хэрэгжүүлэх талаар авсан хууль тогтоомжийн, захиргааны, шүүхийн хүрээнд авсан болон бусад арга хэмжээний талаарх мэдээллийг тэр дундаа хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө, институтын хөгжил зэргийн талаарх мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар гаргаж өгнө үү. Статистик мэдээлэл болон хуваарилсан нөөц зэргийг тодорхой зааж оруулна уу. Оролцогч Улсын хувьд холбоотой гэж үзэж байгаа аливаа бусад мэдээллийг нэмэлтээр гаргаж өгөхийг хүсье.*

413. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг асуудал хариуцсан Хорооноос ирүүлсэн ажиглалт дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2018 онд Хууль зүй, дотоод хэргийн сайд батлан, төлөвлөгөөний дагуу салбар байгууллагууд, харьяа агентлагууд арга хэмжээ авч, хэрэгжүүлсэн.

414. Дээрх хууль тогтоомжуудад нийцүүлэн тодорхой дүрэм, журмуудыг мөн шинэчлэн батлах захиргааны арга хэмжээнүүд авсан болно. Тодруулбал Гадаадын иргэнийг саатуулах байрны дотоод журам, Шинээр хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ял эдлүүлэх хорих анги болон хорих ангийн зэрэглэлийг тогтоох чиг үүрэг бүхий зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрэм, тогтоолын загвар, Хорих ангийн харуул хамгаалалтын журам, Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам, Хоригдлын ял эдлэх хорих ангийн төрөл, зэрэглэлийг өөрчлөх болон хорих ангийг солих тухай санал гаргах журам, Сахилгын байр, тусгаарлах тасалгааны нөхцөл, журам, Баривчлах байрны дотоод журам, Нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн дэглэм, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг албан тушаал дэвшүүлэх, бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэх журам, Хоригдлыг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, аймгийн нэгдсэн эмнэлэгт шилжүүлэн эмчлүүлэх журам зэргийг баталсан.

Ковид-19 цар тахлын үе дэх гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл шалтгааныг судлан түргэвчилсэн үнэлгээ хийсэн. Үнэлгээний зөвлөмжид тулгуурлан Ковид-19 цар тахлын үе дэх гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах чиглэлээр нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөөний арга тусламж” гарын авлага, сургалтын модулийг тус тус хэвлүүлэн олон нийтэд түгээсэн.

2020 онд батлагдсан Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай

хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13-т Засгийн газар төрөлжсөн асрамжийн газар, түүнчлэн эрүүлжүүлэх, баривчлах, цагдан хорих байр, хорих ангид байгаа болон бусад хэлбэрээр эрх чөлөө нь хязгаарлагдсан иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, халдвараас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эм, эмнэлгийн хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулах ажлыг хариуцан, арга хэмжээ авахыг хуульчилсан.

### ДҮГНЭЛТ

415. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Монгол Улсын Хүний эрхийн комиссын бүтцэд бий болгох эрх зүйн үндсийг тавьсан нь тус улсад эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх бие даасан, хараат бус механизм бий болгох эрх зүйн орчныг бүрдүүллээ.

416. Монгол Улсын Засгийн газар Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийгэхийн эсрэг олон улсын конвенцийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлж, хэрэгжилтийг зохион байгуулах тал дээр хүчин чармайлт гаргаж байгаа болно.

---000---

НАЙМДУГААР БҮЛЭГ

**ХҮЧЭЭР АЛГА  
БОЛГОХООС БҮХ  
ХҮНИЙГ ХАМГААЛАХ  
ТУХАЙ НҮБ-ЫН  
КОНВЕНЦ**

## **8.1 ХҮЧЭЭР АЛГА БОЛГОХООС БҮХ ХҮНИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ НҮБ–ЫН КОНВЕНЦИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН АНХНЫ ТАЙЛАН**

1. Монгол Улс нь Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенцийн хэрэгжилтийн анхны тайланг конвенцийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу бэлтгэн хүргүүлж байна. Энэхүү тайлан нь 2014 оны 10 дугаар сараас 2018 оны 7 дугаар сар хүртэлх хугацааг хамарсан болно.

2. Монгол Улс нь конвенцэд 2007 оны 2 дугаар сарын 6–ны өдөр гарын үсэг зурсан бөгөөд УИХ–аас уг конвенцийг соёрхон батлах хуулийг 2014 оны 10 дугаар сарын 09–ний өдөр баталсан.

3. Монгол Улсад хүнийг хүчээр алга болгосон гэмт хэргийн тохиолдол одоогоор бүртгэгдээгүй байна. Иймд энэ тайланд энэ төрлийн гэмт хэргийг хориглосон хууль эрх зүйн орчны талаарх мэдээллийг тусгалаа.

### **Ерөнхий мэдээлэл**

4. Монгол Улс нь Зүүн хойд Азид, хойд өргөргийн 41°35' болон 52°, зүүн уртрагийн 87°44' болон 119°56' солбилцолд байрладаг, далайд гарцгүй, эх газрын улс бөгөөд 1562,0 мян.кв.км нутаг дэвсгэртэй. Нутаг дэвсгэрийн нийт талбайн дийлэнх хэсгийг говь, тал хээрийн бүс, 10 хүрэхгүй хувийг ой мод эзэлдэг. Ашигт малтмал, түүний дотор алт, зэс, уран, чулуун нүүрсний үлэмж хэмжээний баялаг нөөцтэй улс юм. Оросын Холбооны Улстай хойд талаараа 3543 км, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай өмнө талаараа 4709.6 км хиллэдэг. Нутгийн баруунаас зүүн цэг хүртэл 2392 км, хойноос өмнө цэг хүртэл 1259 км урттай.

5. Монгол Улс нь 1992 онд ардчилсан шинэ Үндсэн хуулиа батлан мөрдөж эхэлсэн, Парламентын засаглалтай орон бөгөөд Улсын Их Хурал (Парламент), Монгол Улсын Ерөнхийлөгчийг 4 жил тутам тус тус сонгодог. Түүнчлэн орон нутгийн сонгуулийг 4 жил тутам явуулж, 21 аймаг (аймаг нь сумдад, сум нь багт хуваагддаг) болон нийслэл (нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороодод хуваагддаг) өөрөө удирдах (иргэдийн хурлыг) байгууллагыг сонгодог.

6. Монгол Улс нь 2017 оны жилийн эцсийн байдлаар 3 сая 178 мянган хүн амтай байна. Нийт хүн амын 49.2 хувь нь эрэгтэйчүүд, 50.8 хувь нь эмэгтэйчүүд, хүйсийн харьцаа 96.7 байна. Нийт хүн амд 0–14 насныхны эзлэх хувийн жин 30.4, 15–64 насанд 65.7, 65, түүнээс дээш насанд 3.9 байна.

### **Хүчээр алга болгохыг хориглосон хуулийн нийтлэг хүрээ**

7. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан

шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэж заасан.

8. Монгол Улс нь эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажлын хүрээнд Улсын Их Хурлаас Эрүүгийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Прокурорын тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг тус тус шинэчлэн баталсан бөгөөд эдгээр хуулиуд нь 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэллээ. Мөн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг 2013 онд батлан мөрдөж байна.

9. Эрүүгийн шинэ хуульд анх удаагаа хүнийг хүчээр алга болгох үйлдлийг гэмт хэрэгт тооцон хуульчилсан болно.

10. Монгол Улс нь ижил төрлийн олон улсын гэрээ, хэлэлцээр болох Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад 1974 онд, тус пактын нэмэлт 1 дүгээр протоколд 1991 онд, 2 дугаар протоколд 2012 онд, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцид 2002 онд, тус конвенцийн нэмэлт протоколд 2015 онд, Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэмд 2000 онд тус тус нэгдэн орсон болно.

## **Конвенцийн зүйл тус бүрт холбогдох мэдээлэл**

### **1 дүгээр зүйл**

11. Дээр дурдсаны дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэж заасан.

12. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө” гэж заасан.

13. Мөн Цагдаагийн ба цэргийн алба хаагч, төрийн албан хаагч онц байдлын үед хүч, галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэхдээ хууль зөрчсөн, бүрэн эрхээ хэтрүүлсэн, түүнчлэн албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх хуулийн зохицуулалттай /Онц байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйл/.

### **2 дугаар зүйл**

14. Хүчээр алга болгох гэмт хэргийн үндсэн элемент болох төрийн албан хаагчаас эрх чөлөөг хязгаарлах бусад хэлбэрүүд баривчлах, саатуулах, хулгайлах зэргийг

Эрүүгийн шинэ хуульд Хүнийг хууль бусаар хорих, хүчээр алга болгох /13.4 дүгээр зүйл/, Хууль бусаар баривчлах, саатуулах /13.9 дүгээр зүйл/ –аар тус тус хууль бусаар хорих, баривчлах, саатуулах, хүчээр алга болгох зэргээр хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг зөрчсөн үйлдлийг гэмт хэрэгт тооцоод байна.

15. Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан тодорхой тохиолдолд хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг хязгаарлахаас бусад үед хүний үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлахыг хуулиар хатуу хориглосон ба хуульд заасны дагуу энэ эрх, эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд зөвхөн шүүхийн зөвшөөрлөөр прокурорын хяналтан дор хийхээр хуульд нарийвчлан зохицуулсан.

### **3 дугаар зүйл**

16. Энэ зүйлийн дагуу Орлоцогч улс бүрт төрөөс эрх олгогдоогүй, дэмжлэг, зөвшөөрөлгүйгээр хүчээр алга болгосон үйлдлийг мөрдөн шалгах үүргийг хүлээлгэсэн билээ. Монгол Улсад хүчээр алга болгох үйлдлийг гэмт хэрэгт тооцсон. Түүнчлэн хүчээр алга болгох гэмт хэрэгтэй төстэй хүн хулгайлах, хүнийг хууль бусаар баривчлах, саатуулах, хүн худалдаалах үйлдлийг гэмт хэрэгт тооцож хуульчилсан.

17. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны харьяалал тогтоох нийтлэг үндэслэл нь нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу явагдана.

### **4 дүгээр зүйл**

18. Эрүүгийн хуулийн 13.4 дүгээр зүйлд хүнийг хууль бусаар хорих, хүчээр алга болгох, 13.9 дүгээр зүйлд хууль бусаар баривчлах, саатуулах гэмт хэргийг тусгасан. Эдгээр гэмт хэрэгт Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг зөрчсөн үйлдлүүд хамаарч байгаа.

19. Өөрөөр хэлбэл, хүний халдашгүй чөлөөтэй байх эрх нь хуулиар хамгаалагдсан ба энэ эрхийг зөвхөн хуульд заасны дагуу хязгаарлах боломжтой. Тодруулбал, гэм буруу нь шүүхээр тогтоогдсон этгээдийг шүүхийн шийдвэрээр эрх чөлөөг нь хязгаарлах ял /хорих, зорчих эрхийг хязгаарлах/ эдлүүлэх, эсхүл шалгагдаж байгаа этгээдийг тухайн гэмт хэрэгт нь холбогдуулан мөрдөн шалгах үед Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу баривчлах, цагдан хорих боломжтой. Бусад тохиолдолд хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд хэн ч халдах ёсгүй юм.

20. Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд “хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлах, өмчлөх эрхэд нь халдах, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах, гэм буруутайд тооцох, эрүүгийн хариуцлага хүлээлгэх”-ийг хориглосон ба хуульд зааснаас бусад тохиолдолд хүнийг хорьсон, баривчилсан, цагдан хорьсон тохиолдолд даруй суллах арга хэмжээ авахаар заасан.

21. Эрүүгийн хуульд “хүнийг хүчээр алга болгох” гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнийг тусгахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг буюу эрх бүхий этгээд хүнийг хууль бусаар хорих, баривчлах, саатуулах гэмт хэргүүдийн бүрэлдэхүүнтэй уялдуулан тусгасан байна.

22. Тодруулбал, “хүнийг хууль бусаар хорьсон нь хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийн шинжгүй” бол хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүн байна. Хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд “мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүгч хүнийг хууль бусаар хорьсон, хууль бусаар нууж эрх чөлөөг нь хязгаарласан, эсхүл хорьсон, эрх чөлөөг нь хязгаарласан талаархи мэдээллийг нууж, мэдээлэл өгөхөөс татгалзаж эрх чөлөөг нь хязгаарласны улмаас бусдын хууль ёсны эрх, ашиг сонирхолд нь хохирол, хор уршиг учруулсан” үйлдлийг хамруулсан. Түүнчлэн хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн нь эрүүгийн хуулийн тусгай ангид заасан бусад гэмт хэргийн шинжгүй байна. Өөрөөр хэлбэл, хүнийг хууль бусаар хорьсон үйлдэл нь эрүүгийн хуулийн тусгай ангид заасан “хүн худалдаалах”, “хүн барьцаалах”, “хүнийг хулгайлах” гэх зэрэг хүний халдашгүй чөлөөтэй байх эрхэд халддаг боловч тухайн гэмт хэргийн онцлогт хамаарах зорилгогүй байна.

23. Үүнээс гадна хүнийг хүчээр алга болгох гэмт хэрэг нь Эрүүгийн хуульд заасан өөр нэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг болох “хууль бусаар баривчлах, саатуулах” гэмт хэргийн шинжгүй байна. Эрүүгийн хуулийн 13.9 дүгээр зүйлд энэ гэмт хэргийг “эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж хүний эрх чөлөөнд халдсан, баривчилсан, саатуулсан” гэх гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй байхаар заасан.

### **5 дугаар зүйл**

24. Эрүүгийн хуулийн 29 дүгээр бүлэгт “Хүн төрөлхтөний аюулгүй байдал, энхтайвны эсрэг гэмт хэрэг”-ийг төрөлжүүлэн нэгтгэсэн ба энэ бүлгийн 29.5 дугаар зүйлээр “төрлөөр устгах” үйлдлийг гэмт хэрэгт тооцсон.

25. Энэ гэмт хэргийн бүрэлдэхүүнд “үндэс, угсаа, арьсны өнгө, шашны тодорхой бүлгийг устгах зорилгоор хүнийг алсан, хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан, төрөлтийг хүчээр зогсоосон, хүүхдийг бусад бүлэгт шилжүүлсэн, албадан зайлуулсан, амьдралын өөр нөхцөл бий болгох замаар тэднийг бүхэлд нь, хэсэгчлэн устаж үгүй болоход хүргэсэн, хүчээр сураггүй алга болгосон” үйлдлийг багтаасан.

26. Үүнээс гадна Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд нэг онцлог зохицуулалт байдаг нь Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд зааснаар “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлэх” тухай юм. Энэ нь Монгол Улсын олон улсын гэрээ бусад дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлэх эрх зүйн үндэслэл юм.

### **6 дугаар зүйл**

27. Энэ заалтын дагуу Эрүүгийн хуулийн хүнийг хүчээр алга болгохтой холбоотой заалтад Мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүгч хүнийг хууль бусаар хорьсон, хууль бусаар нууж, эрх чөлөөг нь хязгаарласан, эсхүл хорьсон, эрх чөлөөг нь хязгаарласан талаархи мэдээллийг нууц, мэдээлэл өгөхөөс татгалзаж эрх чөлөөг нь хязгаарласны улмаас бусдын хууль ёсны эрх, ашиг сонирхолд хохирол, хор уршиг учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан /Эрүүгийн

хуулийн 13.4 дүгээр зүйл/.

28. Мөн Эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж хүний эрх чөлөөнд халдсан, баривчилсан, саатуулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан /13.9 дүгээр зүйл/ юм.

### **7 дугаар зүйл**

29. Эрүүгийн хуулийн 13.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хүнийг хууль бусаар хорьсон нь хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийн шинжгүй бол нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан.

30. Мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүгч хүнийг хууль бусаар хорьсон, хууль бусаар нууж эрх чөлөөг нь хязгаарласан, эсхүл хорьсон, эрх чөлөөг нь хязгаарласан талаархи мэдээллийг нууж, мэдээлэл өгөхөөс татгалзаж эрх чөлөөг нь хязгаарласны улмаас бусдын хууль ёсны эрх, ашиг сонирхолд нь хохирол, хор уршиг учруулсан нь энэ хуулийн тусгай ангид заасан бусад гэмт хэргийн шинжгүй бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

31. Харин энэ гэмт хэргийг хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж; хоёр, түүнээс олон хүний эсрэг үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

32. Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг; хохирогчийн эрүүл мэндэд хүнд хохирол учруулж үйлдсэн, эсхүл хохирогч нас барсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж хүндрүүлэх нөхцөлтэйгээр заасан.

33. Харин “Эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж хүний эрх чөлөөнд халдсан, баривчилсан, саатуулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ” /13.9 дүгээр зүйл/.

34. Мөн 13.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Энэ гэмт хэргийг өс хонзон, шунахай, хувийн сэдэлтэйгээр үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар эрх хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан нь конвенцийн гэмт хэргийн онц ноцтой шинжийг харгалзан зохих шийтгэлийн оногдуулна гэсэн заалтыг манай хуульд бүрэн тусгалаа олсон гэж үзэж байна.

35. Түүнчлэн Эрүүгийн хуулийн 6.5 дугаар зүйлд Ял хөнгөрүүлэх нөхцөл байдлыг заасан бөгөөд мөн зүйлийн 1.5 дахь хэсэгт өөрийгөө илчилсэн, гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг олоход тусалсан бол шүүх эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ хөнгөрүүлж болохоор зохицуулалтыг тусгасан.

36. Төрлөөр устгах гэмт хэрэгт “Үндэс, угсаа, арьсны өнгө, шашны тодорхой бүлгийг устгах зорилгоор ... эсхүл хүчээр сураггүй алга болгосон бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял” шийтгэхээр болсон /29.5 дугаар зүйл/.



### **8 дугаар зүйл**

37. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд заасны дагуу гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно.

38. Гэмт хэрэг үйлдсэнээс хойш дараахь хугацаа өнгөрсөн нь тогтоогдвол яллагдагчаар татаж болохгүй байхаар заасан. Үүнд:

- a) “энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн;
- b) энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг арван таван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван хоёр жил өнгөрсөн;
- c) энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг арван хоёр жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг хорин жил хүртэл тогтоосон ба бүх насаар хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэнээс хойш хорин жил өнгөрсөн.”

39. Харин Эрүүгийн хуульд “Үндэс, угсаа, арьсны өнгө, шашны тодорхой бүлгийг устгах зорилгоор хүнийг алсан, эсхүл хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан, эсхүл төрөлтийг хүчээр зогсоосон, эсхүл хүүхдийг бусад бүлэгт шилжүүлсэн, албадан зайлуулсан, эсхүл амьдралын өөр нөхцөл бий болгох замаар тэднийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн устаж үгүй болоход хүргэсэн, эсхүл хүчээр сураггүй алга болгосон” үйлдлийг мөн адил эрүүгийн гэмт хэрэгт тооцож, Хүн төрөлхтөний аюулгүй байдал, энхтайвны эсрэг гэмт хэрэг гэж үзсэн байна. Хүн төрөлхтөний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тоолохгүй байхаар хуульчилсан.

### **9 дүгээр зүйл**

40. Монгол Улс нь өөрийн нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн хүнд Эрүүгийн хуулиараа эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарах хилийн чанадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутаг, усан, агаарын орон зайд байгаа Монгол Улсын усан онгоц, агаарын хөлөгт гэмт хэрэг үйлдсэн хүнд энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг. Харин Гадаад улсын дипломат дархан эрх, эрх ямба эдэлж байгаа хүн Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдвэл түүнд энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэхийг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу шийдвэрлэдэг /Эрүүгийн хуулийн 1.5 дугаар зүйл/.

41. Монгол Улсын иргэнийг гэмт хэрэгт мөрдөн шалгуулах, ял шийтгүүлэхээр гадаад улсад шилжүүлэн өгөхгүй. Гэхдээ Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна гэмт хэрэг үйлдсэн Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу гэмт хэрэгт шалгуулах, ял эдлүүлэхээр гадаад улсад шилжүүлэн өгч болно. Хүсэлт гаргагч улсын хуульд зааснаар цаазаар авах ял оногдуулах, эрүү шүүлт тулгах хангалттай үндэслэл байгаа тохиолдолд гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг тухайн улсад гэмт хэрэгт мөрдөн шалгуулах, ял шийтгүүлэхээр шилжүүлэн өгөхгүй гэсэн хуулийн зохицуулалттай /Эрүүгийн хуулийн 1.7 дугаар зүйл/.

42. Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны харьяалал”-ын асуудлыг зохицуулдаг бөгөөд уг хуульд Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг болон Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарах хилийн чанадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутаг, усан, агаарын хөлөгт гарсан гэмт хэргийг харьяалан шийдвэрлэхээр заасан.

43. Дээрх хуулийн 43.5 дугаар зүйл /Шилжүүлэн өгөх зорилгоор цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх/ –д заасны дагуу Гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтийг хангаж шилжүүлэн өгөх хууль зүйн үндэслэл байвал түүнийг баривчлан шилжүүлж өгөх хүртэл цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай прокурорын саналыг шүүх хэлэлцэж шийдвэрлэдэг. Шилжүүлэн өгөх цаг, хугацаа, газрыг хүсэлт гаргасан гадаад улсын эрх бүхий байгууллагад прокурор мэдэгдэнэ. Гэхдээ ингэж цагдан хоригдсон этгээдийг 30 хоногийн дотор шилжүүлж аваагүй бол шүүхийн шийдвэрээр суллана. Суллагдсан этгээдийг шинээр хүсэлт гаргасан тохиолдолд дахин цагдан хорьж болохоор зохицуулсан.

44. Мөн хуулийн 42.4 дүгээр зүйлд Мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтийг биелүүлэх асуудлыг зохицуулсан. Шүүх, прокурор, мөрдөгч нь гадаад улсын холбогдох байгууллага, албан тушаалтны мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай хүсэлтийг энэ хуульд заасан нийтлэг журмын дагуу биелүүлэх үүрэгтэй. Гэхдээ уг хүсэлтийг биелүүлэхэд тухайн улстай байгуулсан олон улсын гэрээнд заасан бол гадаад улсын мөрдөн шалгах ажиллагааны хэм хэмжээг хэрэглэж болно.

45. Харин хүсэлтийг биелүүлэхэд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон тухайн асуудалтай холбогдох олон улсын гэрээнд заасан шаардлагыг хангаагүй, Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалд харшлах, Монгол Улсын хуулийг зөрчиж байвал шалтгааныг зааж, хүлээн авсан баримт бичгийг буцаахаар зохицуулсан.

46. Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.13 дугаар зүйлийн 10.1 дахь хэсэгт “яллагдагчийг цагдан хорих шийдвэр гаргаснаас хойш 2 цагийн дотор яллагдагчийг цагдан хорьсон талаар түүний гэр бүлийн арван найман насанд хүрсэн гишүүн, эсхүл өмгөөлөгч, гадаад улсын иргэн бол тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газарт, тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газар байхгүй бол гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэнэ” гэж, 31.6 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Мөрдөгч сэжигтнийг баривчилснаас хойш 6 цагийн дотор тухайн сэжигтнийг баривчилсан талаар түүний гэр бүлийн арван найман насанд хүрсэн гишүүн, эсхүл өмгөөлөгч, гадаад улсын иргэн бол тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газарт мэдэгдэнэ” тус тус заасан. Ингэж мэдэгдсэнээр гадаад улсын иргэд консулын туслалцаа авах бүрэн боломжтой юм.

47. Одоогоор тус улс нь Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх харилцааг зохицуулсан гэрээг **19** улстай, Гэмт этгээд шилжүүлэх харилцааг зохицуулсан туслалцааны гэрээг **15** улстай тус тус байгуулсан байна.

### **11 дүгээр зүйл**

48. Монгол Улсад хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь хүнлэг бус, хэрцгий, хүний нэр төр, алдар хүндийг гутаах шинжгүй байна /Эрүүгийн хуулийн 6.1 дүгээр зүйл/. Монгол

Улсын олон улсын гэрээний дагуу гэмт этгээдийг хүсэлт гаргасан улсад шилжүүлэхээс бусад тохиолдолд гэмт хэрэг үйлдэгдсэн нутаг дэвсгэрт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын хяналт, шүүхээр хэрэгт хянан шийдвэрлэх ажиллагаа явагдана.

49. Шүүх шийдвэрээ гаргахдаа шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдсэн нотлох баримтад тулгуурласан, тэдгээрийг тал бүрээс нь бүрэн, бодитой шинжилсний үндсэн дээр дүгнэлт хийсэн, гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж, хэргийн зүйлчлэлийг зөв тогтоосон, шүүгдэгчийг гэм буруутайд тооцсон бол гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, гэм буруутай этгээдийн хувийн байдал, гэм буруугийн хэр хэмжээ, ялыг хүндрүүлэх буюу хөнгөрүүлэх бүх нөхцөл байдлыг харгалзан гэм буруутай этгээдэд хуульд заасан тохирсон ялыг оногдуулдаг.

50. Монгол Улс нь “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенц”-д 2000 онд нэгдэн орсон бөгөөд тус конвенцийн заалтуудыг эрүүгийн хууль тогтоомжтой бүрэн нийцүүлсэн. Тухайлбал: Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд Төрийн албан хаагч тайлбар, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял, шийтгэл оногдуулах, ялгаварлах зорилгоор өөрөө, эсхүл бусад этгээдийг хатгаж, зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрч байгаагаа илэрхийлж бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан.

51. Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхагдахгүйгээр хуулийн этгээд бүр хөрөнгө, орлого, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын хэлбэрээс үл хамааран хууль, шүүхийн өмнө тэгш байхаар хуульчилсан.

## **12 дугаар зүйл**

52. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд /Хүний халдашгүй байх эрхийг хангах/ энэ хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлах, өмчлөх эрхэд нь халдах, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах, гэм буруутайд тооцох, эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг хориглоно гэж заасан.

53. Мөн хуульд зааснаас бусад тохиолдолд шүүхийн зөвшөөрөлгүй, эсхүл шүүхийн шийдвэрт зааснаас илүү хугацаагаар баривчлагдсан, цагдан хоригдож байгаа хүнийг прокурор даруй суллана. Хүнийг баривчлах үед түүнд баривчилсан шалтгаан, үндэслэлийг мэдэгдэж, өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, шүүхэд гомдол гаргах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг сануулах асуудлыг тодорхой зааж өгсөн.

54. Монгол Улсын дотоодын хууль тогтоомжид иргэн өргөдөл, гомдлоо чөлөөтэй гаргах эрхийг баталгаажуулан зааж өгсөн. Тухайлбал: Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 12 дахь хэсэгт: “Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй” гэж заасан байдаг.

55. Мөрдөгч, прокурор нь гэмт хэрэг үйлдсэн, үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай гомдол, мэдээллийг хүлээн авах үүрэгтэй. Гэмт хэргийн талаарх гомдол,

мэдээллийг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд тухайн гомдол гаргасан, мэдээлэл өгсөн хүн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу гомдол гаргаж болно.

56. Мөрдөгч гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг хянан үзээд гэмт хэргийн шинж байгаа эсэхийг тогтоох шаардлагатай бол гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор үзлэг хийх, шинжилгээнд зориулж дээж, хурууны хээ, ул мөрний хэв авах, гэрчээс мэдүүлэг авах, хэрэгт ач холбогдол бүхий тээврийн хэрэгсэл, мөнгө, эд зүйлийг хурааж авах, мөрдөн шалгах ажиллагаа явуулж болдог.

57. Мөрдөгч, прокурор нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалгаж хянасны үндсэн дээр хэргийн бодит байдлыг тогтоохын тулд хэргийн бодит байдлыг нотлохын тулд мөрдөгч, прокурор хуульд заасан бүх арга хэмжээг авч яллагдагч, шүүгдэгчийг яллах, цагаатгах, ял хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдлыг эргэлзээгүй тогтоох үүрэгтэй байдаг.

### **13 дугаар зүйл**

58. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 43 дугаар бүлэгт Тогтоол биелүүлэх зорилгоор хүнийг шилжүүлэн авах, шилжүүлэн өгөх асуудлыг зохицуулсан. Прокурор тухайн этгээдийг баривчлах, цагдан хорих саналыг шүүхэд хүргүүлж шилжүүлэн өгөх хүртэл цагдан хорих бөгөөд прокурор гадаад улсын хүсэлт тавьсан эрх бүхий байгууллагатай холбогдож шилжүүлэн өгөх газар, цаг хугацааг тохиролцож, шилжүүлэн өгөх ажиллагааг цагдаагийн байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

59. Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасан нь олон улсын эрх зүйн хэм хэмжээ үндэсний эрх зүйн хэм хэмжээтэй зөрчилдвөл олон улсын хэм хэмжээг шүүх хэрэглэх боломжтой байдгаар тайлбарлана. Цаашид шинээр байгуулах гэмт этгээдийг шилжүүлэх тухай эрх зүйн туслалцааны хоёр талт гэрээ хэлэлцээрт энэ төрлийн гэмт хэргийг үйлдсэн этгээдийг шилжүүлэх асуудлыг тусгахаар ажиллаж байна.

### **14 дүгээр зүйл**

60. Монгол Улс нь одоогоор 15 улстай гэмт этгээдийг шилжүүлэх болон 19 улстай эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хоёр талт олон улсын гэрээг байгуулан ажиллаж байна. Эдгээр гэрээний хүрээнд талууд харилцан бие биедээ эрх зүйн туслалцаа үзүүлэх бүрэн боломжтой.

### **15 дугаар зүйл**

61. Монгол Улс нь 14 дүгээр зүйлд заасны дагуу бусад улсуудтай байгуулсан эрх зүйн туслалцааны гэрээний хүрээнд хамтран ажиллах боломжтой.

### **16 дугаар зүйл**

62. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 42.1 дүгээр зүйлд заасны дагуу эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа хүсэх Мөрдөн шалгах ажиллагаа

явуулах тухай хүсэлт гаргах бөгөөд гадаад улсын нутаг дэвсгэрт мэдүүлэг авах, үзлэг, нэгжлэг, туршилт хийх, эд хөрөнгө хураан авах болон тус хуульд заасан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах шаардлагатай бол уг асуудлыг эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай болон олон улсын бусад гэрээ, хэлэлцээрийн дагуу гүйцэтгэнэ.

63. Тус улсад одоогоор хүчээр алга болгох гэмт хэргийн бүрэлдэхүүнийг агуулсан хэрэг, үйлдэл бүртгэгдээгүй, энэ чиглэлээр хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон түүнд хяналт тавих прокурорын байгууллагад гомдол, мэдээлэл ирээгүй байна.

### **17 дугаар зүйл**

64. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт: “Халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална гэж заасан.

65. Мөн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт: Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно” гэж зааж өгсөн.

66. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар бүлэгт яллагдагчийн эрх, түүний баталгааны асуудлыг зохицуулсан. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хэвийн явагдах нөхцөлийг хангах зорилгоор яллагдагчийн үйлдсэн гэмт хэргийн шинж, хувийн байдлыг харгалзан таслан сэргийлэх арга хэмжээг шүүх, прокурор, мөрдөгчийн шийдвэрээр авахаар зохицуулагдсан.

67. Яллагдагч ямар хэрэгт яллагдаж байгаага мэдэх эрхтэй бөгөөд яллагдагчаар татсан, таслан сэргийлэх арга хэмжээ авсан шийдвэртэй танилцана. Хуульд заасан үндэслэлээр дуудагдсан баривчлагдсан сэжигтэнд ямар хэрэгт яллагдаж байгааг тайлбарлах үүргийг мөрдөгч, прокурорт хүлээлгэсэн байна. Сонгосон ялын талаар бичгээр болон амаар тайлбар гаргаж улмаар баримт сэлт гаргаж өгөх, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах эрхтэй. Шүүх, прокурор, мөрдөгч нь яллагдагч өөрийгөө өмгөөлөх эсхүл өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэх боломжоор хангах үүрэгтэй.

68. Монгол Улсын хуулийн дагуу түр саатуулах байр, цагдан хорих байр, баривчлах байр болон хорих ангийг байгуулан ажиллуулж байна.

### **Түр саатуулах байр**

69. Цагдаагийн албаны тухай хуулийн 26.1 дүгээр зүйлд заасны дагуу Цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэг, зөрчил үйлдсэнд сэрдэгдэж байгаа хүний нэр, хаягийг тодруулах, гэмт хэрэг, зөрчилд холбогдуулан шалгах, албадан саатуулах үндэслэл байгаа эсэхийг тогтоох зорилгоор хүнийг 6 цаг хүртэл хугацаагаар түр саатуулж болно. Цагдаагийн алба хаагч хүнийг түр саатуулсан даруй тухайн хүний талаар 18 насанд хүрсэн гэр бүлийн гишүүн, өмгөөлөгч, ойр дотны хүнд нь мэдэгдэж, энэ тухай тэмдэглэл үйлдэнэ. Хүнийг түр саатуулах үндэслэл арилсан тохиолдолд түүнийг даруй суллана. Түр саатуулах байрны дэглэм, журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

### **Цагдан хорих байр**

70. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.12 дугаар зүйлд заасны дагуу Шүүхийн зөвшөөрөлгүй баривчлагдсан сэжигтнийг гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай баримт байхгүй, гэмт хэрэг үйлдэж байх үед, эсхүл үйлдсэн дор нь барина гэдгийг зөрчиж баривчилсан бол шүүгч суллах шийдвэр гаргана.

71. Баривчилснаас хойш 48 цаг дуусч, сэжиглэгдэж байгаа хүнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах прокурорын шийдвэр, цагдан хорих шүүхийн шийдвэр ирээгүй бол баривчлах байрны дарга мөрдөгч, прокурор, шүүгчид мэдэгдэж, түүнийг суллана.

72. Мөн Баривчлагдсан сэжигтэн, эсхүл цагдан хоригдсон яллагдагч, шүүгдэгч энэ хуульд заасан хүсэлт, гомдол гаргасан бол баривчлах байр, цагдан хорих байрны захиргаа 12 цагийн дотор хаягаар нь хүргүүлнэ.

73. Мөн хуулийн 7.7 дугаар зүйлд заасны дагуу Баривчлагдсан сэжигтэн, цагдан хоригдсон яллагдагч, шүүгдэгч нь түүнийг баривчилсан, цагдан хорьсон нь хууль ёсны эсэхийг шүүхээр хянуулах, хууль бусаар баривчилсан, цагдан хорьсон бол суллуулахаар шүүхэд гомдол гаргах эрхтэй. Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх, прокурор, мөрдөгчийн хууль зөрчиж учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх гомдол гаргах эрхтэй.

### **Баривчлах байр**

74. Зөрчлийн тухай хуульд заасны дагуу шүүхийн шийдвэрээр оногдуулсан баривчлах шийтгэлийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гүйцэтгэдэг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу Баривчлах төв болон баривчлах байр нь баривчлах шийтгэлийг эдлүүлэх зориулалтын өрөө, тасалгаа, харуул хамгаалалт бүхий барилга байгууламжтай байх бөгөөд баривчлагдсан этгээдийн байрлах өрөө нь олон улсын стандартад нийцсэн байна. Баривчлах байрны дотоод журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталдаг. Баривчлах байрны дотоод журамд баривчлагдсан этгээдийг хүлээн авах, байрлуулах, суллах, баривчлах байранд хөтлөх бүртгэл, түүний агуулга, баривчлах байрны өрөөнд байлгахыг зөвшөөрөх эд зүйл, баривчлагдсан этгээдээс гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх уулзалт хийх, утсаар яриулах, илгээмж, захидал хүлээн авах, хуваарилах,

гадаалах, харуул хамгаалалтын ажлын зохион байгуулалт, эрүүл ахуйн шаардлага, баривчлагдсан этгээдийн бие, эд зүйлд үзлэг хийх, тэдгээрийг хураан авах, хадгалах, хүлээлгэн өгөх, баривчлах байранд байсан хугацааны шууд зардлыг тооцох, захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх ажлыг зохион байгуулах, баривчлагдсан этгээдэд чөлөө олгох, баривчлагдсан этгээдийг хөдөлмөрлүүлэх, баривчлах байрны үйл ажиллагаанд хяналт тавих гэх зэрэг асуудлыг тусгадаг.

### **Хорих анги**

75. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу шүүхийн шийтгэх тогтоол /магадлал/–оор хорих ялаар шийтгүүлсэн этгээдийн хорих ялыг биечлэн эдлүүлдэг.

76. Хорих ял эдлэхээр хуваарилагдан ирсэн ялтныг гүйцэтгэх ажил, харуул хамгаалалт эрхэлсэн дэд дарга, төлөөлөгч, нийгмийн ажилтан, тоо бүртгэлийн ажилтан, эмч, ерөнхий жижүүр /ээлжийн дарга/–ийн бүрэлдэхүүнтэй комисс хүлээн авдаг. Ялтныг хүлээн авахдаа шүүхийн хүчин төгөлдөр болсон шийтгэх тогтоол, эсхүл магадлал, иргэний цахим үнэмлэх, төрсний гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар зэрэг иргэний баримт бичиг, хэрэв тийм бичиг баримт байхгүй бол иргэний бүртгэлийн байгууллагын албан ёсны зурагтай лавлагаа, эрүүл мэндийн даатгалын болон халамжийн дэвтэр, ялтныг тухайн хорих ангид хуваарилсан эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэдэг. Ялтан тухайн хорих ангид ял эдлэхээр ирсэн талаар түүний ар гэрт нь нэн даруй мэдэгдэж, хорих ангийн байршил, уулзалтын хуваарь, хориглох эд зүйлсийг танилцуулдаг.

77. Харин хорих ялаар шийтгүүлсэн өсвөр насны хоригдлын ялыг сургалт–хүмүүжлийн тусгай байгууллагад эдлүүлдэг.

### **18 дугаар зүйл**

78. Манай улс эрх бүхий албан тушаалтнаас хуульд заасан үндэслэлээр гаргасан шийдвэрийн дагуу сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх нөхцөл, журмыг тодорхойлох, тэдгээртэй холбогдсон харилцааг бие даасан хууль буюу Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулиар зохицуулдаг.

79. Тус хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Гагцхүү Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх бүхий албан тушаалтнаас гаргасан захирамж, тогтоол нь баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх үндэслэл болно” гэж заасан.

80. Мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт Баривчлагдсан, цагдан хоригдсон этгээд нь энэ хуулиар хязгаарласнаас бусад Монгол Улсын иргэний эрх, эрх чөлөө эдэлж, үүрэг хүлээнэ. Монгол Улсын нутаг дэвсгэрт баривчлагдсан, цагдан хоригдсон гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын Үндсэн хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, энэ хууль болон бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд тусгайлан зааснаас бусад тохиолдолд Монгол Улсын иргэний адил эрх, эрх чөлөө эдэлж, үүрэг хүлээнэ.

81. Хоригдсон этгээдийн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоос үл хамааран энэ хууль нэгэн адил үйлчилнэ.

82. Хоригдсон этгээдийн хэргийг шалгаж байгаа буюу хянан шийдвэрлэх гэж байгаа хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, өмгөөлөгч, прокурор, шүүгч түүнтэй уулзахаар хорих байранд үнэмлэхээ үзүүлж нэвтрэх эрхтэй байдаг /11 дүгээр зүйл/.

83. Хоригдох этгээдийг хорих байранд хүлээн авахдаа хорих байрны захиргаа хувийн хэрэг нээх бөгөөд түүнд дараахь зүйлийг хавсаргана:

- тухайн этгээдийг хорих тухай шийдвэр;
- хоригдох этгээдийн гэрэл зураг;
- хоригдох этгээдийн хурууны хээний дарц (дактокарт);
- эргэлт, уулзалт, хувцас сольсон талаархи тэмдэглэл;
- хорих байранд ороход түр хураалгасан бичиг баримт, эд зүйлс, мөнгө, үнэт зүйл;
- хоригдох этгээдийн хувийн байдлын талаархи мэдээлэл;
- эрүүл мэндийн байдал, биеийн жингийн талаархи мэдээлэл;
- өлсгөлөн зарласан, эмчид үзүүлсэн, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч, өмгөөлөгчийг дуудуулсан зэрэг үйл явдлын талаархи тэмдэглэл;
- хорих байранд ирсэн болон суллагдсан он, сар, өдөр, цагийн талаархи тэмдэглэл зэргийг тусгахаар зааж өгсөн.

84. Дараахь байгууллага, албан тушаалтны шийдвэр нь хоригдсон этгээдийг суллах үндэслэл болно:

1. хуульд заасан журмын дагуу гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж;
2. прокурорын болон прокуророор батлуулсан хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн тогтоол;
3. хуульд заасан хорих хугацаа нь дууссан этгээдийг суллах тухай хорих байрны даргын эсхүл прокурорын тогтоол.

85. Хорих байрны захиргаа нь хоригдсон этгээдийг суллах тухай энэ хуулийн суллах үндэслэл бүхий тогтоол, захирамжийг хүлээн авмагц холбогдох этгээдийг нэн даруй суллах үүргийг хүлээдэг. Хорих байрны дарга нь хоригдсон этгээдийг хуульд заасан хорих хугацаа дуусах болсон тухай 24 цагаас доошгүй хугацааны өмнө хорих шийдвэр гаргасан албан тушаалтанд болон харьяалах прокурорт бичгээр мэдэгдэх үүрэгтэй. Эрх бүхий албан тушаалтанд мэдэгдсэн боловч хоригдсон этгээдийг цааш нь үргэлжлүүлэн хорих, эсхүл суллах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр хорих байрны захиргаанд ирээгүй бол хорих байрны дарга өөрийн тогтоолоор хуульд заасан хорих хугацаа дуусмагц хоригдсон этгээдийг нэн даруй суллана.

86. Хорих байрны үйл ажиллагаа, нөхцөл, журмын хэрэгжилтэд Улсын ерөнхий прокурор болон түүний харьяа прокурорууд хяналт тавина.

87. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх ажиллагаанд хяналт тавих эрх бүхий прокурор болон хэрэг хянаж байгаа прокурор нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1. хорих байранд ямар ч цагт саадгүй нэвтрэх;



2. хоригдсон этгээд, бусад хүмүүстэй уулзах;
3. хоригдсон этгээдийн хувийн хэрэг болон шаардлагатай бусад материалтай танилцах;
4. өргөдөл, санал, гомдол, хэрэг зөрчлийг хянах, шалган шийдвэрлэхээр заасан.

88. Ингэж баталгаажуулсан нь дээрх конвенцийн заалт, шаардлага бүрэн биелэгдэж байгаагийн тод илрэл юм.

89. Хорих байранд өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, халдваргүйжүүлэх ажлыг эрүүл мэндийг хамгаалах холбогдох хууль тогтоомжид заасны дагуу явуулна. Хорих байрны захиргаа нь хоригдсон этгээдийн эрүүл мэндийг хамгаалахуйц ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангах үүрэгтэй байдаг.

### **19 дүгээр зүйл**

90. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд хүн хувийн нууцаа хамгаалах, хамгаалуулах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаажуулж, хуулиар хамгаалахаар заасан.

91. Ийнхүү Монгол Улсын Үндсэн хуульд хувь хүний нууцыг хуулиар хамгаалахаар заасны дагуу Хувь хүний нууцын тухай хуулийг 1995 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр баталсан.

92. Уг хуулийн 2 дугаар зүйлээр хувь хүний нууц гэдэгт “Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн нууцалсан бөгөөд задруулбал тухайн хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг ойлгох ба мөн хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу хувь хүний нууцын төрөлд захидал харилцааны нууц, эрүүл мэндийн нууц, хөрөнгийн нууц, гэр бүлийн нууц болон хуулиар тогтоосон бусад нууц”-г ойлгохоор заасан.

93. Тодруулбал, дээр дурдсанчлан эрүүл мэндийн нууц нь хувь хүний нууцад хуульд заасны дагуу хамаарах ба уг эрүүл мэндийн нууцад тухайн хувь хүний бие эрхтний гажиг, нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад өвчнөөр өвчилсөн тухай мэдээллийг хамруулж ойлгоно.

94. Харин Монгол Улсын батлан хамгаалах болон үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол, иргэдийн эрүүл мэнд, хууль ёсны эрх ашигт хохирол учруулахгүйн үүднээс зайлшгүй шаардлагатай онцгой тохиолдолд төрийн холбогдох эрх бүхий байгууллага /албан тушаалтан/-ын шийдвэрээр хувь хүний эрүүл мэндийн болон бусад нууцыг хуульд заасан тодорхой хүрээнд ил болгож болох ба үүнээс бусад тохиолдолд ил болгохыг хориглодог.

95. Хувь хүний нууцын тухай хуульд “хуулиар тусгайлан эрх олгогдсон төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу хувь хүний нууцтай танилцаж” болохоор заасны дагуу буюу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.11 дүгээр зүйлд заасны дагуу “Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууцыг хуулиар хамгаалах ба энэхүү эрхийг зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хязгаарлаж” болохоор зохицуулсан.

96. Түүнчлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх аливаа ажиллагааг эрүү шүүлт, хүнлэг бус харьцаанаас ангид байлгах зорилгоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх

тухай хуулийн 1.9 дүгээр зүйлд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжлох, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, гэрчээс мэдүүлэг авахдаа тэдэнтэй хүнлэг бусаар харьцаж, нэр төр, алдар хүнд, бие махбод, сэтгэл санаанд хохирол учруулах арга хэрэглэх”-ийг хориглосон.

## 20 дугаар зүйл

97. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлээр аливаа хүний халдашгүй, чөлөөтэй байх, чөлөөтэй зорчих зэрэг үндсэн эрх, эрх чөлөөг баталгаажуулж, зөвхөн хуульд зааснаас бусад тохиолдолд энэхүү эрх, эрх чөлөөнд халдахыг хатуу хориглосон.

98. Тодруулбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд сэжигтнийг баривчлах, цагдан хорих, яллагдагчийг хорьж мөрдөх зэргээр эрх чөлөөг нь хязгаарлан нийгмээс тусгаарлах тохиолдолд “зөвхөн шүүгчийн зөвшөөрөлтэй”-гээр хуульд заасан үндэслэл, журамд нийцүүлэн хязгаарлаж болохоор тодорхой тусгасан.

99. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зарчмын нэг нь үндэслэл, журмаас гадуур хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлах, өмчлөх эрхэд нь халдах, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах, гэм буруутайд тооцох, эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг хориглосон. /ЭХХШТХуулийн 1.8 дугаар зүйл/

100. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч /”оролцогч”-ийг тус хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.13-т зааснаар ойлгоно/ болж байгаа хүнийг баривчлах, цагдан хорих, зорчих эрхийг нь хязгаарлах арга хэмжээг зөвхөн шүүхийн зөвшөөрлөөр авах үндэслэл, журмыг тус хуульд тодорхой заасан.

101. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд конвенцийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрх чөлөө нь хязгаарлагдсан хүний төрөл садан, тэдний төлөөлөгч буюу тэдний өмгөөлөгчид 18 дугаар зүйлд заасан мэдээллийг авах эрхийг хязгаарласан зохицуулалт тусгагдаагүй.

102. Хуулийн хамгаалалтад байгаа бөгөөд эрх чөлөөг нь зөвхөн шүүхийн хяналтын доор хязгаарлаж буй тохиолдолд дурдсан мэдээллийг авах эрхийг хязгаарласан хуулийн зохицуулалт байхгүй тул конвенцийн 2 дугаар зүйлд тодорхойлсон үйлдэл болох, 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчих асуудал байхгүй болно.

103. Конвенцийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (a)-гаас (g) хүртэлх мэдээллийг авах, уг мэдээллээр хангах, хариуцлага хүлээх байгууллага, албан тушаалтны талаарх хуулийн заалт, үндэслэлийн тухай конвенцийн 17 дугаар зүйлээс харна уу.

104. Эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүний төрөл садан, тэдний төлөөлөгч буюу өмгөөлөгчид нь тухайн хүний эрх чөлөөг хязгаарласан нь хууль ёсны эсэх асуудлыг шүүхэд тавихаасаа өмнө 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан мэдээллийг саадгүй шуурхай олж авах боломжийг бүрдүүлсэн зохицуулалт хуульд тусгагдсан болно.

105. Тухайлбал, мөрдөгч сэжигтнийг баривчилснаас хойш 6 цагийн дотор тухайн сэжигтнийг баривчилсан талаар түүний гэр бүлийн арван найман насанд хүрсэн гишүүн, эсхүл өмгөөлөгч, гадаад улсын иргэн бол тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газарт мэдэгдэнэ /ЭХХШТХуулийн 31.6 дугаар зүйл/.

106. Шүүх яллагдагчийг цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах шийдвэр гаргасан тохиолдолд цагдан хорих шийдвэр гаргаснаас хойш 2 цагийн дотор яллагдагчийг цагдан хорьсон талаар түүний гэр бүлийн арван найман насанд хүрсэн гишүүн, эсхүл өмгөөлөгч, гадаад улсын иргэн бол тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газарт, тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газар байхгүй бол гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэхээр заасан / ЭХХШТХуулийн 14.13 дугаар зүйл/.

107. Баривчлагдсан сэжигтэн түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцаж, хуулбарлаж авах, баривчилсан үндэслэлийн талаар мөрдөгчөөр тайлбарлуулах эрхтэй.

108. Конвенцийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан мэдээллийг саадгүй олж авсан тохиолдолд эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүний төрөл садан, тэдний төлөөлөгч буюу өмгөөлөгч тухан хүний эрх чөлөөг хязгаарласан нь хууль ёсны эсэх асуудлыг шүүхэд тавьж шийдүүлэх боломжтой болох юм. Энэ тохиолдолд шүүхэд хандах асуудал нээлттэй ямар нэг хориг саад байхгүй болно.

109. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.13 дугаар зүйлд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүн, хуулийн этгээд хуулиар хамгаалагдсан эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсэн, хөндөгдсөн гэж үзвэл уг эрхээ сэргээлгэхээр шүүхэд хандах эрхтэй болох, мөн хуулийн 1.14 дүгээр зүйлд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсэн, хөндөгдсөн гэж үзэж байгаа хүн, хуулийн этгээд өөрийгөө өмгөөлөх, эсхүл өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй байхаар заасан.

110. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 17 дугаар зүйлд хоригдсон этгээдийн эдлэх эрхийг тодорхой зааж өгсөн. Тухайлбал:

- өөрийн эрх, үүрэг, хорих байрны дотоод журам, өргөдөл, гомдол, хүсэлт гаргах эрхийн талаар мэдээлэл, тайлбар авах;
- өөрийн хувийн аюулгүй байдлыг хангуулах;
- хорих байрны дарга болон хорих байрны үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий албан тушаалтантай хорих байранд ажиллах үеэр нь хувиараа уулзах;
- өмгөөлөгчтэй уулзах, хууль зүйн туслалцаа авах;
- улсын нууцтай холбоотой болон гэмт үйлдэлд холбогдолтой урвуулан ашиглаж болзошгүйгээс бусад, өөрийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах баримт бичиг, бичлэгийг биедээ хадгалах;
- ном, сонин, сэтгүүл, ариун цэврийн хэрэгсэл өрөөндөө байлгах;
- энэ хуулиар тогтоосон хэмжээний илчлэгтэй хоол, түүнчлэн унтах байр, дэвсгэр, хучлагаар хангагдах;
- шөнийн цагт 8 цагаас багагүй хугацаагаар унтаж амрах;
- эмнэлгийн тусламжийг Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан журмын дагуу авах;

- хорих байрны дотоод журамд заасны дагуу захидал, цахилгаанаар харилцах, бичгийн хэрэгсэл ашиглах;
- хорих байрны дотоод журам зөрчихгүйгээр шашны зан үйл үйлдэх;
- хорих байрны дотоод журамд заасан хугацаагаар салхинд гарах;
- боловсрол, мэдлэгээ дээшлүүлэх, шаардлагатай сурах бичиг, ном ашиглах;
- эргэлт авах;
- иргэний эрх зүйн хэлцэлд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан оролцох;
- өөрт холбогдох асуудлаар болон хорих байрны нөхцөл, журам, үйл ажиллагааны талаар аль ч байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол, хүсэлт гаргах.

111. Хоригдсон этгээдийг хорих шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтны буюу түүний удирдах дээд албан тушаалтны бичгээр олгосон зөвшөөрлөөр төрөл садан болон бусад хүмүүстэй уулзуулж болно. Хоригдсон гадаад улсын иргэн нь эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлөөр хорих байрны захиргаагаар дамжуулан өөрийн улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газрын ажилтантай уулзаж болно.

## **21 дүгээр зүйл**

112. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд баривчлагдсан, цагдан хоригдсон, хоригдсон этгээдийг суллах тухай зохицуулалтыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрт тусгасан. Тухайлбал, тус хуулийн 31.5 дугаар зүйлд сэжигтнийг хуульд заасны дагуу шүүхийн зөвшөөрөлгүй баривчлахдаа хууль бусаар баривчилсан бол прокурор даруй суллахаар, мөн ийнхүү баривчилснаас хойш 48 цаг дуусч, сэжиглэгдэж байгаа хүнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах прокурорын шийдвэр, цагдан хорих шүүхийн шийдвэр ирээгүй бол баривчлах байрны дарга нь мөрдөгч, прокурор, шүүгчид мэдэгдэж, түүнийг суллах зохицуулалтыг тусгасан.

113. Түүнчлэн эрх чөлөө нь хязгаарлагдсан этгээд суллагдсан гэдгийг баталгаажуулах зорилгоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд сулласан тухай магадлагаа олгохоор, өсвөр насны сэжигтнийг суллахдаа түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчийн аль нэгэнд хүлээлгэн өгөхөөр тус тус зохицуулсан.

114. Үүнээс гадна дээрх хуульд цагдан хоригдож байгаа шүүгдэгчийг цагаатгасан, ял эдлэхээс чөлөөлсөн, ял оногдуулахгүйгээр тэнссэн, эсхүл түүнд хорихоос өөр төрлийн ял оногдуулсан, хэргийг хэрэгсэхгүй болгосон бол цагдан хоригдож байгаа шүүгдэгчийг шууд суллахаар зохицуулсан.

115. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчимд хүний халдашгүй байх эрхийг хангах зарчим багтдаг. Энэ тухай Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд заасан бөгөөд хуульд зааснаас бусад тохиолдолд шүүхийн зөвшөөрөлгүй, эсхүл шүүхийн шийдвэрт зааснаас илүү хугацаагаар баривчлагдсан, цагдан хоригдож байгаа хүнийг прокурор даруй суллахаар заасан байдаг.

116. Яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг авах, өөрчлөх, хүчингүй болгох асуудлыг шүүх хэлэлцүүлэг хийж шийдвэрлэх ба шүүхийн хэлэлцүүлэгт

прокурор, яллагдагчийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг оролцуулах ба хүсэлт гаргасан тохиолдолд яллагдагчийг өөрийг нь оролцуулахаар, яллагдагчийн өмгөөлөгч хүрэлцэн ирээгүй бол томилогдсон өмгөөлөгч оролцуулахаар мөн хуульд заасан /ЭХХШТХуулийн 14.13 дугаар зүйл/.

117. Шүүхээс гаргасан яллагдагчид авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгох шийдвэрийг даруй биелүүлнэ. Энэ тохиолдолд шүүхийн хэлэлцүүлэгт яллагдагчийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч заавал оролцох тул цагдан хоригдсон хүн суллагдана гэдэг мэдээлэл авсан байх учраас найдвартай нягтлан шалгах боломжтой болно.

118. Баривчлагдсан сэжигтний хувьд:

- Баривчилснаас хойш 48 цаг дуусч, сэжиглэгдэж байгаа хүнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах прокурорын шийдвэр, цагдан хорих шүүхийн шийдвэр ирээгүй бол баривчлах байрны дарга мөрдөгч, прокурор, шүүгчид мэдэгдэж, түүнийг суллана.
- Сэжигтнийг суллахдаа түүнийг ямар үндэслэлээр, хэзээ, хаана, хэний шийдвэрээр баривчилсан, хэзээ, хэний шийдвэрээр сулласан тухай магадлагаа олгоно.
- Баривчлагдсан өсвөр насны сэжигтнийг суллахдаа түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчийн аль нэгэнд хүлээлгэн өгнө.
- Мөрдөгч сэжигтнийг сулласан тухай тэмдэглэл, баривчлах ажиллагаатай холбоотой материалыг 24 цагийн дотор прокурорт хүргүүлнэ /ЭХХШТХуулийн 31.12 дугаар зүйл/.
- Баривчилсан сэжигтнийг суллах, энэ тухай холбогдох албан тушаалтанд мэдээлэх, тэмдэглэл үйлдэх, хүүхдийг бол хүлээлгэн өгөхөөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тодорхой заасан тул баривчилсан хүнийг үнэхээр сулласан гэж найдвартай нягтлан шалгах боломж бүхий байдлаар суллах явдлыг хангасан зохицуулалттай гэж үзэж болно.

## **22 болон 23 дугаар зүйл**

119. Нээлттэй, хаалттай хорих анги, сургалт–хүмүүжлийн тусгай байгууллага, цагдан хорих төв, байр, нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэг, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд ажиллаж байгаа алба хаагчдад зориулсан сургалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2015 оны 12 дугаар сарын 31–ний өдрийн А/274 дүгээр тушаалаар батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад албаны сургалт зохион байгуулах журам”–аар зохицуулан ажилладаг. Сургалтын хөтөлбөр 2 төрлөөс бүрдэх бөгөөд *үндсэн сургалтаар* Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллаж буй алба хаагчийн хувьд зайлшгүй мэдвэл зохих хууль тогтоомж, хүний эрх, байгууллагын ёс зүй, цэргийн хэргийн мэдлэг, албаны бэлэн байдлыг хангах чиглэлийн сургалтыг, *чиглүүлэх сургалтаар* алба хаагчийн ерөнхий мэдлэг, харилцаа, зан байдал, өөрийгөө хөгжүүлэхэд чиглэгдсэн хувь хүний хөгжил,

багаар ажиллах чадвар зэрэг чиглэлээр сургалтыг явуулдаг.

120. Мөн Цагдаагийн албан хаагчид болон Гадаад иргэн харьяатын газрын албан хаагчдад хүний эрх, шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаарх сургалтуудыг тогтмол зохион байгуулж байна.

#### **24 болон 25 дугаар зүйл**

121. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар бүлэгт гэрч хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах шүүхийн шийдвэр гаргах үндэслэл, шүүхийн шийдвэр гаргах тухай, мөн хуулийн 35 дугаар бүлэгт шүүх хуралдааны турш гэрч, хохирогчийг хамгаалах тухай заасан.

122. Гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээ авах зорилго нь тэднийг айлган сүрдүүлэх, дарамтлах, эрүү шүүлт тулгахаас урьдчилан сэргийлж байгаа болно.

123. Дээрх хуулийн 8.3 дугаар зүйлд хохирогчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хүсэлтийнх нь дагуу ялтныг хорих ялаас хугацааны өмнө суллах асуудлыг шийдвэрлэх хуралдаан, яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авсан, өөрчилсөн, хүчингүй болгосон, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, хаасан, мөрдөн байцаалтыг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хэргийг прокурорт шилжүүлсэн талаар прокурор, мөрдөгч нь хохирогчид мэдээлэл өгөхөөр тусгасан.

124. Түүнчлэн Монгол Улс нь Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийг 2013 онд баталсан бөгөөд энэ хуулиар гэмт хэрэг хянан шийдвэрлэх явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх эрх зүйн үндсийг тогтоосон. Уг хуулиар гэрч хохирогчид аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ болон сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ гэсэн хоёр төрлийн хамгаалалтын арга хэмжээ авдаг. Хамгаалалтад байгаа гэрч хохирогч нь хууль зүйн туслалцаа, сэтгэл зүйн туслалцаа болон эрүүл мэндийн туслалцаа үзүүлж байна.

125. Шаардлагатай тохиолдолд гэрч, хохирогчийн хамаарал бүхий этгээд тухайлбал тэдгээрийн нөхөр /эхнэр/, хамтран амьдрагч, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар болон үрчилж авсан хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охиныг хамгаалалтад авах боломжтой /5.2 дугаар зүйл/.

126. Шүүх, прокурор, мөрдөн шалгах эрх бүхий байгууллага болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь гэрч, хохирогчтой харьцах, насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах чиглэлээр шүүгч, прокурор, мөрдөгчийг чадвар сайжруулах сургалтад хамруулж, хохирогч, гэрчтэй харьцахад баримтлах журам боловсруулж, мөрдүүлж байна /25.4 дүгээр зүйл/.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

**ХҮНИЙ ЭРХИЙН  
ТӨЛӨВ БАЙДЛЫН  
ЭЭЛЖИТ НЭГДСЭН  
ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

## 9.1 МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТАЛААРХ ҮНДЭСНИЙ ИЛТГЭЛ

### I. ТАНИЛЦУУЛГА

#### A. Ээлжит нэгдсэн хэлэлцүүлгийн талаарх Монгол Улсын байр суурь

1. Монгол Улс 1992 онд баталсан шинэ Үндсэн хуулиараа хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгож хүний эрх, эрх чөлөөг жинхэнэ утгаар нь тунхагласан билээ. Өнгөрсөн 18 жилийн хугацаанд Монгол Улс хүний эрх, эрх чөлөөг хамгаалж, иргэн хүн эрхээ эдлэх улс төр, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд онцгой анхаарал хандуулсаар ирлээ. Энэ хүрээнд Монгол Улс гагцхүү үндэсний хэмжээнд төдийгүй олон улсын хамтын нийгэмлэгийн хүрээнд хүний эрх, эрх чөлөөний асуудлаар дуу хоолойгоо өргөж, дэлхийн ардчилсан улс гүрнүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж байна.

2. Нэгдсэн Үндэстний Байгууллага (цаашид “НҮБ” гэх)–ын гишүүн орны хувьд Монгол Улс тус байгууллагаас гаргасан хүний эрхийн хамгааллын талаарх шийдвэр, зөвлөмжийг талархан хүлээн авч, тэдгээрийг олон улсын хэмжээнд хамгаалж, хөхиүлэн дэмжих талаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Түүнчлэн Монгол Улс хүний эрхийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг үндэсний байгууллагуудыг бий болгох, тэдгээрийн чадавхыг бэхжүүлэх асуудлыг төрийн бодлогын хэмжээнд авч үздэг бөгөөд энэ хүрээнд Монгол Улсын Их Хурал (цаашид “УИХ” гэх)–ын 2003 оны 10 дугаар сарын 24–ний өдрийн 41 дүгээр тогтоолоор нийт 4 бүлэг 240 зүйл бүхий “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”–ийг батлан гаргасан бөгөөд уг хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий Үндэсний хөтөлбөрийн хороог байгуулан ажиллуулж байна.

3. Монгол Улсын Засгийн газар “Ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг”–ийн үйл ажиллагаанд оролцох замаар хүний эрхийг хамгаалан бататгах чиглэлээр НҮБ–ын бусад гишүүн орон болон иргэний нийгмийн байгууллагуудтай санал бодол, түүнчлэн туршлага солилцоход бэлэн байна. НҮБ–ын хүрээнд шинээр нэвтрүүлсэн “Ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг” гэх энэ механизм нь өөрийн орны хүний эрхийн төлөв байдлын талаар дэлхий нийтэд мэдээлэхээс гадна цаашдын чиг хандлага, ирээдүйд авч хэрэгжүүлэх зохистой арга хэмжээ зэргийг тодорхойлох бодит боломжийг Монгол Улсад олгож байна. Иймээс Хүний эрхийн Зөвлөлтэй үр дүнтэй харилцан яриа өрнүүлж, олон улсын бусад байгууллага, түүнчлэн иргэний нийгмийн байгууллагуудаас зөвлөгөө авах сайхан бололцоо бүрдэж буй нь Монгол Улсын хувьд олзуурхуштай хэрэг бөгөөд ийм хэлбэрээр цаашид хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд өөрийн чадавхыг бүрэн дүүрэн дайчлах болно.

#### B. Үндэсний илтгэл боловсруулах арга зүй ба зөвлөлдөх ажиллагаа

4. Үндэсний илтгэлд хүний эрхийг хамгаалах, түүнийг хөхиүлэн дэмжих үйл ажиллагааны бодлого, хамрах хүрээ, тэдгээрийн хэрэгжилт болон хэрэгжүүлэх



механизмын талаар тусгав. Түүнчлэн хүний эрхийг хамгаалахад учирч буй хүндрэл, бэрхшээл, тэдгээрийг даван туулах арга замын талаар өөрийн саналыг багтаасан болно.

5. Үндэсний илтгэлийг Хүний эрхийн Зөвлөлийн 2007 оны 6 дугаар сарын 18–ны өдрийн 5/1 дүгээр Тогтоолоор батлагдсан удирдамж болон А/НRC/6/L.24 тоот Баримт бичигт тусгагдсан “Ээлжит Нэгдсэн Хэлэлцүүлэг”-ийн дагуу Мэдээлэл бэлтгэх тухай Ерөнхий Удирдамж зэргийг тус тус баримтлан боловсруулав.

6. Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулсан үндэсний илтгэл бэлтгэх Ажлын хэсэг үндэсний илтгэл бэлтгэх хугацаанд нийт 3 удаа хуралдсан бөгөөд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс (цаашид “ХЭҮК” гэх) болон хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага (цаашид “ТББ” гэх)–ууд болон мэргэжлийн хүмүүстэй санал солилцох уулзалтыг янз бүрийн түвшинд хэд хэдэн удаа хийсэн болно. Тухайлбал Монгол Улсын Засгийн газар НҮБ–ын Хүний эрхийн дээд комиссарын алба (цаашид “ХЭДКА” гэх)–тай хамтран Үндэсний илтгэл бэлтгэх тухай сургалт–семинарыг 2010 оны 1 дүгээр сард Улаанбаатар хотноо зохион байгуулсан бөгөөд дээрх сургалтад төрийн болон ТББ–ын нийт 70 гаруй төлөөлөгч оролцов. Түүнчлэн 2010 оны 2 дугаар сард НҮБ–ын Хөгжлийн хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газар, олон нийтийн байгууллага оролцсон 3 талт зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж илтгэл боловсруулах асуудлаар чөлөөтэй санал бодлоо солилцов. Мөн Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн [www.humanrights.mn](http://www.humanrights.mn) веб хуудсанд үндэсний илтгэл бэлтгэхтэй холбоотой мэдээллүүдийг 2010 оны 05 дугаар сарын 12–ны өдөр байрлуулах зэргээр энэ хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээгээ олон нийтэд тухай бүрт ил тод байлгахад анхаарал түлхүү хандуулав.

## **II. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ, ХӨХИҮЛЭН ДЭМЖИХ ТӨРИЙН МЕХАНИЗМ**

### **А. Үндсэн зорилго**

7. Монгол Улс хүний эрхэмсэг оршихуй, үнэт зүйлсийг хүндэтгэн үздэг. Ийм ч учраас хүн бүр ямар нэгэн алагчлалгүйгээр өөрийн салшгүй эрх, эрх чөлөөгөө эдлэх тэр боломжийг нь бүрдүүлж өгөх үндсэн үүргээ гүнээ ухамсарладаг бөгөөд хүний эрх, эрх чөлөөг дээдлэх нь угаасаа Монгол төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болно.

8. Иргэний болон улс төрийн эрхийн хүрээнд хүний амьд явах, халдашгүй байх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх, эвлэлдэн нэгдэх, тайван жагсаал, цуглаан хийх, түүнд оролцох, чөлөөтэй зорчих, хувийн нууцтай байх эрхийн хамгааллын асуудалд тодорхой хүчин чармайлт гаргадаг бол эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухайд сурч боловсрох, соёл, эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхийг нь өргөжүүлэх замаар иргэний амьжиргааны чанарыг дээшлүүлэхэд голлон үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн хүний хөдөлмөрлөх эрхийг хөхиүлэн дэмжих бодлогынхоо хүрээнд Монгол Улсын Засгийн газар хөгжлийн бэрхшээлтэй болон хөдөлмөрийн хөлсний дундаж хэмжээнээс доогуур орлоготой иргэдэд эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх, тэдгээр иргэдийн хөдөлмөр эрхлэх боломж, бололцоог нэмэгдүүлэхэд анхаарч байна.

Түүнчлэн 2008 онд эрх зүйн туслалцааны төвийг бүх аймаг, дүүрэгт байгуулсан бөгөөд төвийн зорилго нь төлбөрийн чадваргүй, эмзэг бүлгийн иргэд мөнгө, санхүү, нийгмийн гарал үүсэл, байдлаасаа шалтгаалан хууль зүйн туслалцаа авч чадахгүйн улмаас эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд оршиж байна.

9. Монгол Улсын Засгийн газар хууль тогтоомж боловсруулах, бодлого тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэхэд алагчлахгүй байх бодлого барих замаар үндэсний цөөнхийн эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих боломжийг үргэлж эрэлхийлдэг. Тухайлбал Монгол Улсын Үндсэн хуульд үндэсний цөөнхийн эх хэлээрээ суралцах, харилцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг хөндөхгүй байх зохицуулалтыг тусгаснаараа үндэсний цөөнхийн эрхийг баталгаажуулж буй хэрэг юм.

10. Иргэдийнхээ улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хангах зорилгоор хүний эрхийн гэрээний байгууллагуудаас гаргасан буюу тогтоосон олон улсын хэм хэмжээ, стандартыг хэрэгжүүлэхэд ач холбогдол өгч байна. Түүнчлэн иргэдийн эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх үүднээс эрх зүйн албан бус сургалтыг эрх зүйн олон чиглэлээр тогтмол явуулж байна.

### **В. Хууль зүйн орчин ба төрийн механизм**

11. Аливаа улсын Үндсэн хуулийн зорилго нь төрийн эрх мэдлийг хязгаарлахын хирээр иргэдийн эрх, эрх чөлөөгөө гарцаагүй эдлэх боломжийг бататган бэхжүүлэхэд оршдог. Энэ жишгийн дагуу Монгол Улсын шинэ Үндсэн хуулиар хүний үндсэн эрхүүдийг ангилан төрөлжүүлж, тэдгээр эрхүүдийн хөндөгдөшгүй байх баталгааг хангах үүргийг төрд оногдуулсан. Өөрөөр хэлбэл төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэсэн үг.

12. Хүний эрхүүдийг дан ганц Үндсэн хуулиар бус төрөл бүрийн салбар буюу тусгайлсан хуулиудаар давхар зохицуулдаг. Гэхдээ тэдгээр тусгай хуулиуд нь Үндсэн хуулиар тогтоосон хүний үндсэн эрхэнд ямар нэгэн байдлаар харшлах ёсгүй бөгөөд хэрэв ингэсэн тохиолдолд Үндсэн хуулийн шүүх (Цэц)–ээр уг зөрчлийг арилгана. Мөн эрх нь зөрчигдсөн гэж үзэж буй иргэн энэ тухай гомдлоо ХЭҮК–т хандан гаргах боломжтой.

13. Монгол Улс хүний эрхийн олон улсын үндсэн гол гол баримт бичгүүдэд нэгдэн орсон. Тухайлбал Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, түүний нэмэлт I протокол, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, Арьс, үндсээр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын Конвенц, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц, Хүүхдийн эрхийн тухай конвенц, түүний нэмэлт протокол, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай конвенц ба түүний нэмэлт протокол, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын шугамаар баталсан конвенцууд гэх мэт. Хамгийн сүүлд Монгол Улс НҮБ–ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протоколыг 2010 оны 04 дүгээр сарын 23–ны өдөр соёрхон баталлаа.

14. Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль

тогтоомжийн нэгэн адил үйлчилдэг. Иймд дотоодын аливаа хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу эсхүл шинээр хууль батлах зэрэг тохиолдолд дээрх олон улсын гэрээнд харшлахгүй байхаар зохицуулалт хийгддэг.

### **С. Хүний эрхийн байгууллагууд**

15. Хариуцаж буй асуудлынхаа цар хүрээ, түвшин болон чиг үүргээсээ шалтгаалан Монгол Улсын яамдууд өөр хоорондоо харилцан адилгүй байдлаар хүний эрхийг хамгаалах буюу хөхиүлэн дэмжих үйл ажиллагаа явуулдаг. Тухайлбал Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам (цаашид “ХЗДХЯ” гэх) хүний эрхийн хамгааллын бодлогын үндсийг тодорхойлж, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоодог бол Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам хөдөлмөрлөх эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ба бусад нийгмийн хамгааллын салбарт хамаарах эрх, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам сурч боловсрох эрх, Эрүүл мэндийн яам эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхийг тус тус хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг. Эдгээрээс гадна Засгийн газрын хэрэгжүүлэгч болон тохируулагч агентлагууд хүний аливаа нэг эрхээр дагнан ажилладаг бөгөөд энд Хүүхдийн төлөө газар болон Жендэрийн тэгш байдлын үндэсний хороо зэргийг нэрлэж болно.

16. Ийнхүү Монгол Улсад хүний эрхийг хангах асуудалд нэгдмэл хандлагаар хандах, төрийн байгууллагуудын энэ чиглэлээрх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан орон тооны бус Үндэсний хороог байгуулсан бөгөөд уг хорооны ажлын албыг ХЗДХЯ–ны бүтцэд байгуулан ажиллуулж байна. Хорооны дүрмийн дагуу яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүрэгт орон тооны бус салбар хороо байгуулж, нийтдээ 412 салбар хороотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

17. Засгийн газраас хараат бус, бие даасан бүтэц болох ХЭҮК–ын тухай хуулийг 2000 оны 12 дугаар сарын 7–ны өдөр УИХ–аас баталсан бөгөөд 2001 оны 2 дугаар сараас эхлэн ХЭҮК үйл ажиллагаагаа явуулж байна. ХЭҮК нь Үндсэн хууль болон олон улсын гэрээ, конвенцид туссан хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх явдалд хяналт тавих, зөрчигдсөн эрхийг сэргээх, мөн энэ талаар санал гаргах, зөвлөмж боловсруулж төрийн байгууллагуудад хүргүүлэх зэрэг хуульд заасан онцгой эрхүүдийг хэрэгжүүлдэг бөгөөд тэдгээр эрхүүд нь онц байдлын үед ч хэрэгждэг.

### **Д. Хүний эрхийн талаар олон улсын өмнө хүлээсэн үүрэг**

18. НҮБ–ын бүрэн эрхт гишүүний хувьд Монгол Улс нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд тус байгууллагатай нягт хамтран ажиллаж, НҮБ–ын Дүрэм болон Хүний эрхийн түгээмэл тунхаглал (цаашид “ХЭТТ” гэх)–ын дагуу хүлээсэн үүргээ шударгаар биелүүлдэг. Олон улсын хүний эрхийн үндсэн баримт бичгүүдэд оролцогч болохынхоо хувьд Монгол Улс тэдгээрийн хэрэгжилтийн талаарх үндэсний илтгэлүүдээ бэлтгэн, холбогдох гэрээний байгууллагын хурлаар хэлэлцүүлдэг бөгөөд хамгийн сүүлд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн тухай ээлжит тав, Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцийн хэрэгжилтийн талаарх анхдугаар илтгэлийг тус тус хүргүүлж, Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн хэрэгжилтийн талаарх 3, 4 дүгээр илтгэлийг Хүүхдийн эрхийн Хороогоор 2010 онд хэлэлцүүлсэн болно.

### III. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ, ХӨХИҮЛЭН ДЭМЖИХ

#### **Хүний эрхийн талаар хүлээсэн үүргийн хэрэгжилт**

19. Монгол Улсын Засгийн газраас иргэн, улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг баталгаатай эдлэх боломжийг бүрдүүлэхэд анхаарч, ялангуяа нийгмийн эмзэг хэсэг болох хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настнууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн хэрэгжилтэд ач холбогдол өгч байна. Хүний эрхийн хамгааллын талаар дэлхийн улс орнуудад тохиолдож буй ололт амжилт, хувьсан өөрчлөгдөж буй нөхцөл байдал болон хүний эрхийн гэрээний байгууллагуудаас гаргасан санал, зөвлөмж, дүгнэлт зэргийг үндэслэн хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих чиглэлээр Монгол Улсын Засгийн газар дараах үйл ажиллагааг авч хэрэгжүүлж байна.

#### **1. Амьд явах эрх**

20. Хэдийгээр Монгол Улсын Эрүүгийн хуулийн тодорхой заалтуудаар цаазаар авах ял хэрэглэгдэх хэрэг тохиолдлыг тодорхойлсон боловч Монгол Улсын Ерөнхийлөгч Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8-д заасан уучлал үзүүлэх бүрэн эрхийнхээ хүрээнд тус улсад цаазаар авах ялыг хэрэглэхгүй байх тухай өөрийн байр сууриа 2010 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр УИХ-ын индэр дээрээс нийт ард түмэндээ болон олон улсын хамтын нийгэмлэгт хандан илэрхийлсэн. Ерөнхийлөгчийн энэхүү байр сууриар Монгол Улс практикт цаазаар авах ялыг гүйцэтгэхээс түдгэлзэж байгаа юм. Ер нь мөрдөж буй хуулиар 18 нас хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, түүнчлэн эмэгтэйчүүд, 60-аас дээш насны эрэгтэйчүүдэд цаазаар авах ял оногдуулдаггүй.

#### **2. Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх**

21. Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтаар хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй болохыг тодорхойлсон. Үндсэн хуулийн энэ эрхийг хангах зорилгоор Монгол Улс иргэдийнхээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг улам бүр баталгаажуулах үүднээс олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд нэгдэн орох, түүнчлэн дотоодын эрх зүйн актуудад тухай бүр тусган баяжуулах арга хэмжээг тасралтгүй авч ирсэн.

22. Энэ хүрээнд Монгол Улс Озоны давхаргыг хамгаалах тухай Венийн конвенц, Биологийн олон янз байдлын конвенц, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц зэрэг нэр бүхий 14 баримт бичигт нэгдэн орсон. Үндэсний хэмжээнд хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны тухай, Усны тухай, Рашааны тухай, Агаарын тухай, Ойн тухай, Ашигт малтмалын тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай, Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай зэрэг нийт 30 гаруй хуульд тусгасан.

23. Монгол Улсын нийт хүн амын 60 гаруй хувь нь хот, суурин газар оршин сууж байгаагаас нийслэл Улаанбаатар, Дархан–Уул ба Орхон аймаг болон Мөрөн, Чойбалсан зэрэг хот, суурин газрын хөрс, агаарын бохирдол, ногоон байгууламжийн хомсдол зэрэг нь оршин суугчдын эрүүл мэндэд ямар нэг байдлаар нөлөөлж болзошгүй байдалд хүрээд байна.

24. Ундны цэвэр ус нь хүн амын болон хүрээлэн буй орчин эрүүл байхын үндэс юм. Манай улсын хувьд нэг хүнд ноогдох усны хүрэлцээ 13739 м3 байгаа ба хэрэгцээ жилээс жилд нэмэгдэж байна. Манай орны нийт 345 сум, суурингаас 110 нь хатуулаг ихтэй, 99 нь магни ихтэй, 49 нь эрдэсжилт ихтэй, 27 нь хужиртай ус хэрэглэж байна. Гол горхи, булаг шанд, нуур цөөрмийн орчим ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдал асгах, голд машин болон бусад эд зүйл угаах, усыг ариг гамгүй зарцуулах, булаг шандны эхэнд барилга, байгууламж барих зэрэг хууль зөрчсөн үйл ажиллагааг бүрэн зогсоож чадахгүй байгаагаас голын ус бохирдож, нөөц нь багасахад хүрч байна. Мөн түүнчлэн ашигт малтмал олборлолт усны бохирдолд нөлөөлж байна. Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотын хүн амын тоо эрс нэмэгдэхийн хамт усны хэрэглээ ихэссэн нь Төв цэвэрлэх байгууламжаас гарч Туул голд нийлэх хаягдал усны хэмжээ өсөхөд хүргэжээ. Иймд голын дагуух ариун цэвэр, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг шинээр тогтоох, усны эх үүсвэртэй ойролцоох айл өрх, амралтын газрыг нүүлгэх, ил бие засах газар, бохир усны цэгийг устгах, ил хогийг үгүй болгох арга хэмжээ авах бодлогыг холбогдох төрийн байгууллагаас баримтлан ажиллаж байна.

25. Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт, хүний зүй бус үйл ажиллагааны улмаас мөнх цас хайлах, гадаргын ус ширгэх, бэлчээрийн ургамлын гарц муудах, хөрс, ус давсжих, элэгдэх, үржил шимээ алдах, элсний нүүдэл ихсэх, цөлжилт үүсэх зэрэг нь хүний амьдрах орчинг доройтуулахад хүргэж байна. 2007 оны усны тооллогоор 5121 голын 887 нь, 9340 булаг шандны 2096 нь, 3732 нуур тойрмын 1166 нь ширгэсэн байна. Манай орны нийт бэлчээрийн газрын 90 гаруй хувь нь хуурай, хагас хуурай буюу хуурайвтар уур амьсгалтай бүсэд оршдог. Уур амьсгалын өөрчлөлт, хүний хүчин зүйлийн нөлөөнөөс болж нийт нутаг дэвсгэрийн 5.0% нэн хүчтэй, 18.0% хүчтэй, 26.0% дунд, 23.0% сул зэрэглэл, буюу нийт нутгийн 72.0 хувийн талбай бүхий газар нутаг цөлжих аюулд өртөгдсөн байна. Энэ байдалд дүгнэлт хийж, Засгийн газраас 2010 онд “Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”, “Ус” хөтөлбөрийг шинэчлэн баталж, илүү үр дүнтэй арга хэмжээ авахаар ажиллаж байна.

26. Байгаль орчны тэнцвэрт байдал алдагдаж буй зэргээс улбаалан 1992–2002 онуудад их цас, зуд 9 удаа, хүчтэй шороон шуурга 142 удаа, хүн малын гоц халдварт өвчин 42 удаа тохиосон байна. Энэ нь тус орны уламжлалт аж ахуй болох бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг иргэдийн хувьд хүндээр тусч, тэдний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх хангагдахгүй байна. Ийм учраас 2009 онд УИХ–аас малчдын амьдрах нөхцлийг сайжруулах, энэ хүрээнд тэдний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулах үүднээс “Малчдын талаар төрөөс баримтлах бодлого”–ыг тусгайлан батлан, хэрэгжүүлж байна.

### **3. Өмчлөх эрх**

27. 1992 оны шинэ Үндсэн хуулиар өмчлөх эрхийн суурь зохицуулалтыг тодорхойлсон бөгөөд түүнээс хойшхи хугацаанд төрөлжсөн хуулиудаар чөлөөт нийгмийн үндсэн суурь болсон өмчлөх эрхийг баталгаажуулсан, хувийн өмчийг хамгаалахтай холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгосоор ирлээ. Тухайлбал газар, орон сууц, малыг нэг удаа үнэ төлбөргүй хувьчилсан. Монгол Улсын Иргэний хуульд “Өмчлөгч нь бусад этгээдэд хууль болон гэрээгээр олгогдсон эрхийг зөрчихгүйгээр, хуулиар тогтоосон хэмжээ, хязгаарын дотор өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах бөгөөд аливаа халдлагаас хамгаалах эрхтэй” гэж заасан байдаг.

28. Үндсэн хуулиар Монгол Улсын иргэнд газар өмчлүүлж болохоор заасан. Энэхүү заалтыг хэрэгжүүлэх зорилгоор 2002 онд Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулиудыг тус тус батлан гаргаснаар хүний өмчлөх эрхийн эрх зүйн орчин үндсэндээ бүрдэж, өмчийн олон хэлбэрийг чөлөөтэй, тэгш хөгжүүлэх баталгаа болсны зэрэгцээ Монгол Улсад эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн харилцаа дэлхий нийтийн нийтлэг чиг хандлагын дагуу хөгжих үндэс суурь нь болсон байна. Хүний үндсэн эрх болох өмчлөх эрхийг баталгаажуулах, хамгаалах чиглэлээр Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн нэг чухал ажил бол 1997 онд “Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар”-ыг байгуулсан явдал юм. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаа эхэлсэн эхний жилүүдэд бүртгэлийн дийлэнх хувийг төрөөс хувьчилсан орон сууцны өмчлөх эрхийг баталгаажуулах үйл ажиллагаа эзэлж байсан бол 2000 оноос бүртгэлийн төрөл улам өргөн хүрээг хамарч дуудлага худалдаагаар худалдан авсан үл хөдлөх хөрөнгийн, өөрөө барьж бий болгосон үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн болон хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн бүртгэлийн гэх зэргээр өргөжин, бүртгэлийн тоо тогтмол өсч байна. Эл албанаас цаашид иргэдийн өмчлөх эрхийг бүрэн хангах, баталгаажуулах, хамгаалах ажлын хүрээнд хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлыг эрчимжүүлэх, газар болон түүн дээр орших үл хөдлөх хөрөнгийн уялдаа холбоо мэдээллийг оновчтой болгож, мэдээллийн сан бий болгох ажлуудыг ойрын хугацаанд хийж гүйцэтгэх нь чухал ач холбогдолтой бөгөөд энэ нь иргэдийн өмчлөх эрх зөрчигдөхөөс сэргийлэх томоохон алхам болно гэж үзэж байна.

29. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 5 дахь заалтад “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй” гэж заасан бөгөөд эл заалтыг Монгол Улсын Засгийн газар амжилттай хэрэгжүүлж байна.

### **4. Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрх**

30. Ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийн тухай зохицуулалт Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай, Төрийн албаны тухай, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль зэрэг холбогдох эрх зүйн актуудад тусгалаа олон хэрэгжиж буй бөгөөд Монгол Улс хөдөлмөрлөх эрхийн тухай НҮБ-ын 7, Олон улсын

хөдөлмөрийн байгууллага (цаашид “ОУХБ” гэх)–ын 20 гаруй конвенцид нэгдэн орсон болно.

31. Иргэн ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох Монгол Улсын эрх зүйн орчин үндсэндээ бүрдэж байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулиудыг тус тус 2001 онд батлан хэрэгжүүлж байна. Эдгээр хуулиудын хүрээнд Монгол Улсын иргэдэд ажил, хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, гадаадын орнуудад хөдөлмөр эрхлэх нөхцөл, орчинг бүрдүүлэх асуудлуудыг шийдвэрлэсэн. 2010 онд багтаан тус хуулиудыг илүү боловсронгуй болгож, олон улсын нийтлэг хэм хэмжээнд тааруулан шинэчлэн батлуулахаар ажиллаж байна. 2009 оны байдлаар нийт 25.0 мянга орчим иргэдийг гадаадад хөдөлмөр эрхлүүлэхээр зуучилсан. Мөн онд 22568 ажилгүй иргэнийг мэргэжлийн сургалтад хамруулж, 2197472.3 мянган төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлсэн байна.

32. Танил тал харах, шан харамж өгч ажлын байраар хангагдах явдал Монгол Улсад байсаар байгаа хэдий ч хууль, эрх зүй болон хөдөлмөрийн зах зээлийн өрсөлдөөнтэй эдийн засгийн өөрчлөлтөд улам бүр шахагдаж, хэн боловсролтой, мэргэжилтэй, хэн практик дадлагатай, ажил хийх хүсэлтэй нь хүссэн ажилдаа орж ажиллах нөхцөл, орчин бүрдэж байна. Цаашид Монгол Улсын Засгийн газар иргэн хүн ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн харилцаанд тэгш эрхтэйгээр оролцох нөхцлийг бүрдүүлэх талаар шат дараатай олон арга хэмжээг авч ажиллаж байна.

## **5. Эрүүл мэндээ хамгаалуулах эрх**

33. Монгол Улсын Үндсэн хуульд “... эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлнэ...” гэж заасны дагуу иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламжийг алагчлалгүйгээр тэгш, хүртээмжтэй үзүүлж байна. Монгол Улсад Иргэний эрүүл мэндийн даатгалын тогтолцоог 1994 онд бий болгож, эрүүл мэндтэй холбоотой зардлын улмаас санхүүгийн эрсдэлд орохоос иргэдээ хамгаалах боломжийг бүрдүүлэв. УИХ–аас баталсан 2008–2012 оны Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт Эрүүл мэндийн салбарт 22 зорилт тусгагдсан бөгөөд эдгээр зорилтыг хэрэгжүүлэхээр Засгийн газар 96 зүйл бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан ажиллаж байна.

34. Монгол Улс зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг 1991 онд анх боловсруулан гаргаж, эмчилгээнд мөрдөж эхэлснээс хойш Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (цаашид “ДЭМБ” гэх) болон бусад орнууд зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтаа тодорхой хугацаанд шинэчилж байдаг туршлага, эмийн зах зээлтэй уялдуулан эмчилгээний арга барилд гарч буй өөрчлөлт, өвчлөлийн байдал, эмийн бүртгэл, ханган нийлүүлэлт, эмч, эм зүйч нарын саналыг үндэслэн 1993, 1996, 2001, 2005, 2009 онуудад тус тус шинэчилсэн. Эмийн төсөвт жилд 29 орчим тэрбум төгрөг зарцуулж, нэг хүнд ноогдох эмийн зардал ойролцоогоор 8 ам.доллар (13.0 мянган төгрөг), эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй 1 өвчтөнд дунджаар 6.95 нэр төрлийн эм хэрэглэж байна.

35. Эрүүл мэндийн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, төрийн оролцоог

багасгах зорилгоор хүн амд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулахад хувийн хэвшлийн мэргэжлийн эмнэлгийн оролцоог дэмжих зорилгоор эрүүл мэндийн салбарын санхүүжилтэд хувийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх, өмчийн хэлбэрийг үл харгалзан эмнэлгүүдийг даатгалын үйлчилгээнд жигд хамруулах зорилтын хүрээнд 2009 онд эрүүл мэндийн даатгалын сангаас 56.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг улсын болон хувийн хэвшлийн байгууллагуудыг санхүүжүүлж, 2010 онд нийт 76 тэрбум төгрөгийн эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг санхүүжүүлэхээр болов.

36. “Эрүүл монгол хүн” хөтөлбөр Монгол Улсын Засгийн газрын 91 дүгээр тогтоолоор баталж 2006–2008 онд хэрэгжсэн. Хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний өвчлөлийн түвшинг тогтоон, эрт илрүүлэн эмчилснээр хүн амын эрүүл мэндийн байдлыг сайжруулахад хөтөлбөрийн зорилго оршино. Уг хөтөлбөр улсын хэмжээнд нэгдсэн удирдамж, төлөвлөгөө, аргачлалын дагуу хэрэгжсэнээр хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, тэгш байдал, чанарт эерэгээр нөлөөлж байгаагаас гадна сонгогдсон өвчнүүдийг эрт илрүүлэн, эмчилгээнд хамруулснаар үр дүнгээ өгсөн. Ялангуяа, бэлгийн замаар дамжих халдвар, умайн хүзүүний хавдар, цусны даралт ихсэх өвчний эрт илрүүлэлт, эмчилгээ, эрүүлжүүлэлтийн хувь өндөр гарлаа. “Эрүүл монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 15–аас дээш насны 1.020.705 хүн буюу нийт хүн амын 83.6 хувь хамрагджээ.

## **6. Сурч боловсрох эрх**

37. Иргэдийн сурч боловсрох эрхийг Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулж, суурь боловсролыг бүх нийтэд үнэ төлбөргүй эзэмшүүлж байна. Иргэдийн сурч, боловсрох эрхийг хангах тогтолцоо нь албан ба албан бус боловсролын нэгдэл байна. Албан боловсролын тогтолцоо нь сургуулийн өмнөх, 6 жилийн бага, 9 жилийн суурь, 12 жилийн бүрэн дунд боловсрол, мэргэжлийн боловсрол, дээд боловсрол олгох сургалтын байгууллагуудаас бүрдэнэ. Сургуулийн өмнөх насны хүүхдийн 76.7%, бага боловсролын насны хүүхдийн 94.2%, суурь боловсролын насны хүүхдийн 89.8% нь албан боловсролд хамрагдсан. Засгийн газраас орлого багатай, нийгмийн эмзэг бүлгийн хүүхдийг боловсролд тэгш хамруулах зорилгоор “Үдийн цай”, “Хүүхэд бүрт компьютер” хөтөлбөр хэрэгжүүлж, тэднийг хичээлийн хэрэглэл, сурах бичгээр үнэ төлбөргүй хангаж байгаа нь бага, дунд боловсролын түвшинд хүүхэд бүрт суралцах адил тэгш боломжийг олгоход үр дүнгээ өгч байна. Монгол орны хөдөөгийн нүүдэлчин малчдын хүүхдийг сургуульд хамруулах зорилгоор сум, багийн сургуулиудад дотуур байр барьж, зардлыг нь төрөөс хариуцдаг. 2009–2010 оны хичээлийн жилд дотуур байранд амьдрах хүсэлт гаргасан малчдын хүүхдийн 54.6% дотуур байранд амьдарч байна. Гэвч сургуулийн насны хүүхэд сургуулиас завсардах нь бүрэн арилаагүй, 2009 оны 9 дүгээр сарын байдлаар суурь боловсрол эзэмших насны нийт хүүхдийн 0.8% сургуулиас гадуур байгаагийн 61.0% нь хөвгүүд байна. Завсардалт олон шалтгаантай боловч дийлэнх нь ядууралтай холбоотой байна.

38. Монгол Улсын төрөөс боловсролын талаар баримталж буй бодлого нь



иргэдийнхээ эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэх, сэтгэл хангалуун амьдрахад шаардлагатай боловсролын хэрэгцээг чанартай хангах үйлчилгээг төр, хувийн хэвшлийн хамтын оролцоо, санаачилгад тулгуурлан хөгжүүлэхэд оршино. Үүнтэй нийцүүлэн бүх шатны боловсролын агуулгыг шинэчлэх ажил үечлэн хийгддэг бөгөөд ерөнхий боловсролын ахлах сургуулийн шатнаас ажил мэргэжлийн баримжаа олгох, суралцагчид хэрэгцээ сонирхлынхоо дагуу хичээлээ сонгон судлах боломж бүрдүүлж байна. Ерөнхий суурь боловсрол зээмшсэний дараа ахлах сургууль, эсхүл мэргэжлийн боловсролын сургуульд шилжин сурах сонголттой бөгөөд мэргэжлийн боловсролын сургуульд орсон тохиолдолд сургалтын зардлыг төрөөс хариуцаж, суралцах хугацаанд нь дотуур байраар хангаж, тэтгэлэг олгодог. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан тусгай сургуулиас гадна ердийн сургуулиудад тусгай анги зохион байгуулдаг. Монгол Улсын хэмжээнд ерөнхий боловсролын 6 тусгай сургууль хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах үйлчилгээ үзүүлж, бага, суурь, бүрэн дунд боловсрол, мэргэжил эзэмшүүлэх сургалт явуулж байна. Сургуулиас завсардсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дүйцсэн хөтөлбөрөөр боловсрол нөхөн олгож байгаа нь тэднийг амьдрал, хөдөлмөрт бэлтгэхэд дэмжлэг үзүүлсэн хэлбэр болж байна.

39. Дээд боловсролын сургуулиудад суралцах чадвараар нь сонгон шалгаруулж элсүүлдэг. Бага орлоготой, бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй, малчин өрхийн суралцагчдад Сургалтын төрийн сангаар дамжуулан төрөөс санхүүгийн дэмжлэгийг буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл хэлбэрээр олгодог. Сурлагын өндөр амжилт үзүүлсэн, авьяаслаг оюутнуудад нэрэмжит тэтгэлэг, урамшуулал олгож байна. Байнга оршин суудаг газраасаа өөр газарт суралцаж байгаа суралцагчдад орон нутагтаа ирж очих замын зардал, хот суурин газрын оюутнуудад тээврийн зардлын хөнгөлөлтийг төрөөс хариуцан санхүүжүүлдэг.

40. 1990–ээд оноос хэлбэршин төлөвшиж буй албан бус боловсрол нь боловсролын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг юм. Энэхүү боловсрол нь сургууль завсардсан хүүхэд, залуучуудад боловсролыг нөхөн олгох, насанд хүрэгчдийн мэдлэг боловсролоо шинэчлэх хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг орон нутаг дахь гэгээрлийн төв, албан боловсролын байгууллагуудтай хамтран, хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан хүргэж байна. Боловсролын тогтолцооны нэг бүрэлдэхүүн хэсэг болох албан бус боловсролын хэлбэрийг ойрын жилүүдэд иргэдийн насан туршийн боловсролын хэрэгцээг хангах хүртээмжтэй хүчирхэг сүлжээ болгон бэхжүүлэх шаардлагатай байна.

## **7. Сонгох, сонгогдох эрх**

41. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй” гэж баталгаажуулсан. Иргэн төрийг удирдахад оролцох эрхээ төрийн бүх шатны байгууллагад төлөөлөгч сонгох, өөрөө төрийн албан тушаалд сонгогдох буюу томилогдох, ард нийтийн санал асуулгад оролцох зэргээр хэрэгжүүлж байна.

42. Монгол Улс дахь сонгох, сонгогдох эрхийн харилцааг мөн УИХ–ын сонгуулийн

тухай хууль (2005), Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль (1992), Орон нутгийн хурлын сонгуулийн тухай хууль (2007)–иар тус тус зохицуулж буйгаас гадна эдгээр эрх зүйн актыг улам бүр боловсронгуй болгоход УИХ анхааран ажиллаж байна. Тухайлбал өмнө нь тойргийн нэг мандаттай байсан бол шинэ хуулиар олон мандаттай болсон буюу ингэснээр сонгогчдын санал өгөх замаар төрийн үйл хэрэгт оролцох боломжийг жигд хангах, УИХ–д аль болох олон намын төлөөллийг оруулахад чухал алхам болж байна.

43. Сонгуулийн төв байгууллага нь УИХ–ын дэргэд гэж байсныг бие даасан статустай болгож өөрийн үйл ажиллагаа, харилцааг зохицуулах Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийг батлан гаргаснаар Сонгуулийн Ерөнхий хороо (цаашид “СЕХ” гэх) хараат бусаар үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин бүрдэв. Мөн Орон нутгийн хурлын сонгуулийн тухай хуулийг 2007 онд шинэчлэн найруулж нэр дэвших, сонгууль зарлах, сонгуулийг бэлтгэн явуулах ажлын ил тод байдал, сонгуулийн хороодын бүрэн эрх, сонгуулийн үйл ажиллагааны эдийн засгийн баталгаа, сонгуулийн мөрийн хөтөлбөр, сурталчилгааны асуудлыг нарийвчлан зохицуулав.

44. Сонгуулийн ажлын зохион байгуулалт хангалтгүйгээс хөгжлийн бэрхшээлтэй иргэн, цагдан хоригдож буй хүмүүс сонгуульд оролцож чадахгүй байна. Цагдан хоригдож буй хүмүүсийн иргэний бүртгэл, бичиг баримтын асуудлыг сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд шийдвэрлэж, эрхээ эдлэх боломжийг хангах шаардлагатай. Түүнчлэн сонгуульд оролцож чаддаггүй шалтгаанаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 40 орчим хувь нь брайль тэмдэглэгээ байхгүйгээс, 58 орчим хувь нь тэргэнцэртэй хүн орох боломжгүйгээс гэж тайлбарлаж байгаад дүгнэлт хийх шаардлагатай юм.

## **8. Сайн дураар эвлэлдэн нэгдэх эрх**

45. Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиудаар тус тус сайн дураар эвлэлдэн нэгдэх эрхийн харилцааг зохицуулж байна. Эдгээрээс хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуулиар хуулийн этгээдийг бүртгэх ажиллагааг нэг мөр зохицуулж, бүртгэх хугацаа, бүрдүүлэх бичиг баримт, бүртгэхээс татгалзах болон бүртгэлээс хасах үндэслэл зэргийг зааж өгсөн нь иргэдийг эвлэлдэн нэгдэх эрхээ хэрэгжүүлэх нөхцлөөр хангахад чиглэсэн, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй хүргэхэд ач холбогдолтой юм.

46. ТББ–ыг нийгэмд болон гишүүддээ үйлчилдэг гэж хоёр ангилдаг бөгөөд Монгол Улсад олонх ТББ нь “нийгэмд үйлчилдэг” гэсэн статустай байгуулагдаж байгаагаас 2010 оны 4 сарын байдлаар нийт 8.329 ТББ улсын бүртгэлд бүртгүүлснээс 80.0 орчим хувь нь нийгэмд үйлчилдэг, 20.0 хувь нь гишүүддээ үйлчлэхээр үйл ажиллагаагаа явуулж байна. Өнөөгийн практикт ажилчдын хувьд Үйлдвэрчний эвлэл байгуулах, ажил олгогчдын хувьд ТББ байгуулах замаар тус тус эвлэлдэн нэгдэж, эрх ашгаа хамгаалах үйл ажиллагаа явуулж байна. Хэдийгээр хөдөлмөрлөх болон түүнд хамаарах эрхүүдээ хамгаалах гол баталгаа нь үйлдвэрчний эвлэлд нэгдэх эрхээ сайн дураар хэрэгжүүлж, зохион байгуулалтад орох явдал боловч өнөөдрийн байдлаар төрийн захиргааны болон орон нутгийн ихэнх байгууллагуудын дэргэд үйлдвэрчний эвлэл байхгүй байна. Харин төрийн үйлчилгээний байгууллагуудын дэргэд үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд ажиллаж байна.

## 9. Бүтээл туурвих эрх

47. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт Монгол Улсын иргэн бүр “соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй” гэж тунхаглан зарласан байдаг.

48. Монгол Улс ЮНЕСКО, Дэлхийн оюуны өмчийн байгууллагын соёл, урлаг, шинжлэх ухаан, зохиогчийн эрхийн салбар дахь олон улсын холбогдох гэрээ, хэлэлцээрт нэгдэн орж зохих хуулиудыг батлан гаргаснаар бүтээл туурвигч иргэдийг урлаг, шинжлэх ухааны дэвшилд идэвхтэй оролцуулж нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулахыг нь хөхиүлэн дэмждэг. “Оюуны өмчийн үндэсний стратеги” боловсруулах ажлын хэсгийн байгуулан ажиллаж байна.

49. Монголын ард түмний улс орныхоо соёлын амьдралд оролцох, бүтээл туурвих, түгээх, үр шимийг нь хүртэх, соёлын болон утга соёлын өвийг хамгаалах, өвлөн хөгжүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулах эрхийг хуулиар баталгаажуулсан. Уламжлалт мэдлэг, ардын урлагийн бүтээл, уламжлалт технологийг оюуны бүтээлийн хувьд хамгаалах, зүй ёсоор ашиглах, ашигласнаас олох ашгаас хүртэх зэрэг асуудлуудыг зохицуулах эрх зүйн орчин бүрдүүлэх зорилгоор Уламжлалт мэдлэгийг хамгаалах тухай бие даасан хуулийн төслийг боловсруулаад байна.

## 10. Хүйсээр алагчлуулахгүй байх эрх

50. Хүн аль ч байдлаараа алагчлуулахгүй байх эрх зүйн үндсийг Үндсэн хуулийн холбогдох заалтуудаар тогтоосон бөгөөд мөн харилцааг цаашид Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулиар зохицуулж буйгаас гадна Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Үндэсний хөтөлбөрийг 2001 онд, Нийгмийн хамгааллын стратегийн баримт бичгийг 2003 онд тус тус батлан гаргаснаар эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тэднийг ажил хөдөлмөр эрхлэлтэд алагчлуулахгүй байх явдлаас урьдчилан сэргийлэх хууль, эрх зүйн үндсийг тавихад том алхам болсон.

51. 2008 оны байдлаар Монгол Улсын 7–29 насны нийт эрэгтэйчүүдийн 53.4 хувь, эмэгтэйчүүдийн 58.6 хувь нь сургуульд хамрагдаж байсан бол эрэгтэйчүүдийн сургуульд хамрагдалт эмэгтэйчүүдийнхээс 5.2 хувиар доогуур байна. Албан бус хэвшилд ажилладаг насанд хүрээгүй хүүхдийн 64.3 хувь нь хөвгүүд бөгөөд тэдний 58.7 хувь нь сургууль завсардаад байна. 18 нас хүрсэн залуучуудын 12 хувь нь бичиг үсэггүй, цэргийн үүрэгт алба хаагаагүй залуучуудын 20 хувь бичиг үсэгт тайлагдаагүй байна. Эдгээр тоо баримтууд нь Монгол Улсын хувьд хөвгүүдийн боловсрол охидынхоосоо хоцрогдож явааг харуулж байна.

52. Монгол Улсын хөгжил дэвшилд эрэгтэй, эмэгтэйчүүдийг тэгш оролцуулах, тэдний эрх тэгш байдлыг баталгаажуулах талаар төрийн зүгээс тодорхой бодлого барин ажиллаж байна. Тухайлбал НҮБ-ын Мянганы дээд хэмжээний чуулга уулзалтаас 2000 онд гаргасан Мянганы Тунхаглал болон Мянганы Хөгжлийн Зорилтуудыг хэрэгжүүлэх үүднээс 2005 онд УИХ-аас “Монгол Улсын Мянганы Хөгжлийн Зорилт”-ыг баталсан. Үүнд 2015 он гэхэд бүх шатны боловсролын түвшинд хүйсийн ялгааг арилгах, хөдөө аж

ахуйгаас бусад салбарт цалинтай ажил эрхлэж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувийг 50–д, парламентад эмэгтэй гишүүдийн эзлэх хувийг 30–д тус тус хүргэх зэрэг хүйсийн тэгш байдлыг хангах томоохон зорилтуудыг дэвшүүлжээ.

53. Монгол Улсын Засгийн газраас хүйсийн тэгш байдлыг хангах талаар хийж буй томоохон ажлуудын нэг бол “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”-ийн төслийг санаачлан боловсруулж, 2009 оны 7 дугаар сард УИХ–д өргөн бариад буй явдал юм. Монгол Улс жендэрийн хөгжлийн индексээр 140 орноос 94–д, жендэрийн эрх мэдлийн хэмжүүрээр 76 орноос 65–д орсныг дэлхийн хүний хөгжлийн илтгэлд дурдсан байна. Дэлхий дахинд тогтвортой хөгжлийг хангахад жендэрийн тэгш байдал чухал үүрэгтэйг Монгол Улс хүлээн зөвшөөрч жендэрийн чиг хандлагыг хөгжлийн бүхий л бодлого, төлөвлөлтөд нийцүүлэн тусгах явдалд онцгойлон анхаарч байна.

### **11. Халдашгүй чөлөөтэй байх эрх**

54. Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн Эрүүгийн байцаан шийтгэх хууль (цаашид “ЭБШХ” гэх)–иар гэмт хэрэг үйлдсэн хүнийг мөрдөн шалгах, шаардлагатай тохиолдолд баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах зэрэг эрүүгийн процессыг тус бүрт тодорхой зааж өгсөн нь хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэнийг ч дур мэдэн хорихын эсрэг авсан хууль зүйн ач холбогдол бүхий эрх зүйн хэм хэмжээ болсон. Эрүүгийн процессын ажиллагаа явуулах үед хүний эрх зөрчигдөхөөс сэргийлэх, хэдийгээр хуульд заасан журмаар хүний эрхийг хуулийн хүрээнд хязгаарлаж буй боловч хүний угаас заяасан эрхийг хүндэтгэх, түүний эрхийн байдлыг дээрдүүлэх эрх зүйн энэрэнгүй зарчмыг баримтлан зарим нэмэлт, өөрчлөлтийг 2007 онд оруулсан. Тухайлбал ЭБШХ–ийн нэмэлт, өөрчлөлтөөр уг хуулийн 157.1–д “шинжилгээ хийлгэх үед сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, өмгөөлөгч, хохирогч дор дурдсан эрх эдэлнэ.” гэж оруулав. Үүгээр өмгөөлөгч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, хууль зүйн туслалцаа үзүүлэх шаардлагын үүднээс эрхийг нь баталгаажуулсан.

55. Цагдаагийн ажилтнуудын хувьд хүнийг саатуулан шалгах үед тэдэнтэй хуулийн дагуу, мэргэжлийн ёс зүйтэй харьцах тухай журам, стандартыг шинэчлэн боловсруулав. Мөн 2009 онд Цагдаагийн Ерөнхий Газар (цаашид “ЦЕГ” гэх)–аас цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны стандартыг батлан, мөрдүүлж байна.

56. Монгол Улс 1999 онд “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль”–ийг анх баталсан бөгөөд үүгээр анх удаа цагдан хорих байрны стандарт шаардлагыг үндэсний хэмжээнд тогтоож өгснөөрөө чухал ач холбогдолтой болсон. Одоогийн дагаж мөрдөж буй хуулиар 2002 оноос эхлэн цагдан хорих байрны харьяалал өөрчлөгдөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжиж, баривчлах, цагдан хорих зөвшөөрлийг олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээнд нийцүүлж шүүхээр шийдвэрлэхээр тогтоосон. Саатуулах байрны үйл ажиллагаанд өдөр тутам төвийн дарга болон харуул хамгаалалт хариуцсан ахлах байцаагч, төвийн ерөнхий эргүүл хяналт тавьж, 14 хоног тутам Прокурорын газраас шалгалт хийдэг. Мөн дээд шатны байгууллага (УИХ, Засгийн газар, ХЭҮК, ХЗДХЯ

тэдгээрээс томилогдсон ажлын хэсэг, мэргэжлийн байгууллага болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Прокурорын байгууллага гэх мэт)–аас гэнэтийн шалгалт тогтмол хийдэг.

## **12. Шашин шүтэх эрх**

57. Монгол Улс НҮБ–ын гишүүн болсноос хойш хүний эрхийн салбарын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, түүнээс батлан гаргасан эрх зүйн баримт бичгүүдэд нэгдэн орж, хүний эрхийг баталгаажуулах үйл хэрэгт бусад улс оронтой хамтран ажиллаж ирсэн бөгөөд ардчилсан Монгол Улсад бодит биеллээ олсон хүний эрхийн нэг нь шашин шүтэх, эс шүтэх явдал юм. Монгол Улсын Үндсэн хуульд шүтэн бишрэх эрх чөлөөг хуульчлан баталгаажуулж, жинхэнэ утгаараа хэрэгжих боломжийг нээж өгснөөр манай орны иргэдийн шүтэн бишрэх эрх чөлөөтэй болсны дээр бусад шашны урсгал орж ирэх, дэлгэрэх нөхцөл бүрдсэн.

58. Шашин шүтэх эрхийн талаар Үндсэн хуульд “Монгол Улсын иргэн шашин шүтэх, эс шүтэх эрхтэй чөлөөтэй” гэж заасан бөгөөд уг эрхийн харилцааг зохицуулахаар УИХ–аас 1993 онд Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль, 2003 онд “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”, 1994 онд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс “Шашин–сүм хийдийн талаарх төрийн бодлогын үзэл баримтлалын тухай зөвлөмж”–ийг тус тус батлан гаргасан нь хүний шүтэн бишрэх эрх чөлөөг хангахад бодитой нөлөө үзүүлж, тусгалаа олсон билээ. Өнөөгийн байдлаар Монгол Улсад Будда, Христ, Ислам, Бахай, Бөө мөргөл, Мүүн шашны урсгалын нийт 463 байгууллага улсын бүртгэлд бүртгүүлэн үйл ажиллагаа явуулж байгаагийн 50 гаруй хувь нь буддын шашны, 40 орчим хувь нь христийн шашны байгууллага юм.

## **13. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх**

59. “Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй” гэсэн Үндсэн хуулийн заалтаар иргэд болон хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд мэдээлэл нээлттэй байхаар хуульчилсан. Цаашлаад хэвлэн нийтлэх эрхийг баталгаажуулах үүднээс УИХ–аас 1998 онд Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг баталж, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль гаргах, төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт тавихыг хориглосон. Үүнээс гадна 2005 онд Олон нийтийн радио, телевизийн тухай хуулиар төрийн мэдэлд байсан үндэсний радио, телевизийг олон нийтийн радио телевиз болгон өөрчлөх эрх зүйн үндсэн зохицуулалтыг хийсэн. Үүгээр уг телевиз олон нийтийн эрх ашигт үйлчилдэг, тэдний өмнө хариуцлага хүлээдэг, хяналтан дор нь үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус хуулийн этгээд болсон бөгөөд мөн үйл ажиллагаанд нь аливаа этгээд (хувь хүн, албан тушаалтан, байгууллага гэх мэт) хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглосон нь үг хэлэх, хэвлэн нийтлэх эрхийг хангахад чухал түлхэц болсон.

60. Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай харилцааг Иргэний хууль, Эрүүгийн хууль, Зар сурталчилгааны тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Садар самуунтай тэмцэх тухай хуулиудаар тус тус зохицуулж байна.

61. Тайван замаар жагсаал, цуглаан хийх эрхийн хэрэгжилтийн талаар ХЭҮК-оос гаргадаг Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай 2004 оны илтгэлд оруулж, “цуглаан” гэсэн ойлголтыг тодорхойлох, зөвшөөрлийн тогтолцоо, зөвшөөрөл олгох хугацаа, субъектын талаарх зохицуулалтыг хянан үзэж, 2005 оны 11 дүгээр сард УИХ-аас Жагсаал, цуглаан хийх журмын тухай 1994 оны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж гудамж, талбайд жагсаал цуглаан зохион байгуулахад зөвшөөрөл олгодог хуулийн зохицуулалтыг бүртгэлийн зохицуулалттай болгосон.

62. 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр тогтоосон онц байдлын үеэр нийгмийн эмх замбараагүй байдал бий болж, дөрвөн иргэн галт зэвсгийн суманд өртөж, нэг хүн угаартаж нас барсан хэрэг гарсан. Галт зэвсгийн суманд дөрвөн иргэн өртөж нас барсан хэргийг Улсын Ерөнхий Прокурор (Цаашид “УЕП” гэх)-ын дэргэдэх Мөрдөн байцаах алба шалгаж Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлд заасан хүнийг санаатай алах гэмт хэрэгт зургаан албан хаагчийг холбогдуулан мөрдөн байцаалт явуулж гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр, албан тушаалын гэмт хэрэгт холбогдуулан шалгасан цагдаагийн дөрвөн удирдах ажилтныг Монгол Улсын Өршөөл үзүүлэх тухай хуулийн дагуу 2010 оны 2 дугаар сарын 3-ны өдөр тус тус хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Нэг хүн угаартаж нас барсан хэрэгт хууль бус жагсаал, цуглаан, нийтийн эмх замбараагүй байдлыг зохион байгуулж, өдөөн турхирсан зарим нам, хөдөлгөөний тэргүүнүүдэд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаад 2009 оны 07 дугаар сарын 09-ний өдөр батлагдсан Монгол Улсын Өршөөл үзүүлэх тухай хуулийн дагуу хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

#### **14. Хувь хүний нууц халдашгүй байх эрх**

63. УИХ-аас 1995 онд “Хувь хүний нууцын тухай хууль”-ийг батлан гаргасан бөгөөд “Хувь хүний нууц” гэж Монгол Улсын иргэн, гадаадын хүн, харьяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн нууцалсан бөгөөд задруулбал тухайн хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ гэж тодорхойлсноос гадна хувь хүний нууцын төрөл, хамгаалах баталгаа, хувь хүний нууцын талаар шүүхэд гомдол гаргах эрх зэргийг хуульчилсан.

64. Хувь хүний нууцыг хамгаалах зорилгоор шүүх хуралдааныг хаалттай явуулж болох тухай өөрчлөлтийг 2007 онд ЭБШХ-д оруулсан бөгөөд мөн ХЭТТ-д нийцүүлэн иргэний захидал, харилцааны нууцын халдашгүй байдлыг зөрчсөн, энэ хэргийг албан тушаалын байдлаа урвуулж буюу хэтрүүлж, эсхүл тусгай техник хэрэгсэл ашиглаж үйлдсэн хэрэгт ял шийтгэхээр, түүнчлэн хуулиар хамгаалагдсан хувь хүний мэдээллийг задруулсан, олон нийтэд тараасны улмаас бусдад хүнд хор уршиг учирсан бол ял шийтгэхээр тус тус нэмэлт, өөрчлөлтийг Эрүүгийн хуульд 2008 онд оруулсан.

#### **15. Чөлөөтэй зорчих эрх**

65. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 18 дахь хэсэгт “Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй” гэж заасан. Мөн иргэдийн шилжилт

хөдөлгөөнийг Улсын бүртгэлийн тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон Засгийн газрын 2002 оны 214 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам”-аар тус тус зохицуулдаг бөгөөд хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд шилжилт хөдөлгөөнийг зөвхөн хуулиар хязгаарлаж болохоор Үндсэн хуульд заасан нь ХЭТТ-ын үзэл санаатай нийцэж байгаа бөгөөд иргэн хүн чөлөөтэй зорчих эрх чөлөөгөө эдлэх эрх зүйн зохицуулалтын цөм болж байна. Монгол Улсын ХЭҮК-оос жил бүр гаргадаг Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлүүдэд Монгол Улсын иргэн бүр энэхүү эрх, чөлөөгөө бүрэн эдэлж байгааг дурджээ.

66. Монгол Улс Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагад 2008 онд гишүүнээр элсэн орж, тус байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож буй бөгөөд улмаар тус байгууллагаас Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албатай хамтран “Монгол Улс дахь шилжилт хөдөлгөөний менежментийн чадавхыг бий болгох” хөтөлбөрийг эхний шатанд 2 жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

#### **16. Хүүхдийн эрх**

67. Үндэсний хэмжээнд хүүхдийн эрхийг 1996 онд баталсан Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулиар зохицуулдаг. Олон улсын хэмжээнд Монгол Улсын Засгийн газар Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх илтгэлийг 3 удаа, түүний нэмэлт протоколуудын талаарх илтгэлийг 1 удаа Хүүхдийн эрхийн хороогоор тус тус хэлэлцүүлсэн. Сүүлчийн илтгэлийг 2010 оны 1 дүгээр сард хэлэлцүүлж, Хорооноос өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж эхлээд байна.

68. Хүүхдийн эрхийг хамгаалах механизм, бүтэц тогтолцооны хувьд Монгол Улс Ерөнхий сайдаар ахлуулсан Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөлтэй бөгөөд түүний ажлын албаны үүргийг Хүүхдийн төлөө газар хэрэгжүүлдэг. Засгийн газрын 2004 оны 197 дугаар тогтоолоор хүүхдийн төлөө үйл ажиллагааны үндэсний стратегийг баталсан бөгөөд уг стратегид тусгагдсанаар хүүхдийн оролцоог хангах бүтэц тогтолцоог баталгаажуулж, үндэсний болон орон нутгийн хүүхдийн төлөө байгууллагын дэргэд “хүүхдийн чуулган”, “хүүхдийн нэгдсэн зөвлөл”, хүүхдийн чуулганаас сонгогдсон хараат бус “хүүхдийн элч” ажиллаж, бүх шатанд төлөвшөөд байна.

69. Монгол Улсын Засгийн газар хүүхдийн эрхийг хэрэгжүүлэхэд “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийг арав арван жилээр төлөвлөн хэрэгжүүлдэг бөгөөд 2008 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 284 дүгээр тогтоолоор уг хөтөлбөрийн зорилтыг хангах гурав дахь шатны үйл ажиллагааны чиглэлийг батлан хэрэгжүүлж, улмаар 2010–2011 онд үр дүнг тооцож дараагийн арван жилийн хөтөлбөрийг гаргахаар төлөвлөж байна. Засгийн газар 2008 оны 6 дугаар сарын 25-ны 261 дүгээр тогтоолоор Хүүхдийн төлөө сангийн дүрмийг шинэчлэн, удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталсан. Үүний үр дүнд Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу хүүхдийн хөгжил, хамгааллын бодлого, чиглэлд нийцсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, хүүхдийн эрх ашиг, сонирхлыг хамгаалах зорилгоор зарим онцгой нөхцөлд

тусламж үзүүлэх, хүүхэд, өсвөр үеийнхний гишүүнчлэлтэй ТББ-ын зарим үйл ажиллагааг дэмжих санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх боломж нэмэгдэж, сангийн төсвийн зонхилох эх үүсвэрийг төрөөс санхүүжүүлэхээр болсон.

70. Хүүхэд хамгааллын тогтолцооны нэг хэсэг болох хүүхдийн утасны үйлчилгээг төлөвшүүлэх зорилгоор Хүүхдийн төлөө газрын дэргэд “Найз 19–79” утасны сүлжээг бий болгон, тогтмол ажиллуулж байна. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны харьяа Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар асрамж, халамжийн төвүүдэд байгаа хүүхэд, шилжилт хөдөлгөөн бүрийн мэдээллийг сар бүр гарган хяналт тавьдаг бөгөөд түүнчлэн “Хүүхдийн асрамж, халамж, хамгааллын үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага MNS 5852:2008” Монгол Улсын стандартыг батлан 2009 оноос мөрдүүлж байна.

### **17. Гадаадын иргэний эрх**

71. Монгол Улсын Үндсэн хуульд нутаг дэвсгэртээ байгаа гадаадын иргэн болон харьяалалгүй хүний эрх, үүргийг Монгол Улсын хууль, түүнчлэн гадаадын иргэний хувьд тухайн улстай байгуулсан гэрээгээр тогтоох бөгөөд уг иргэний харьяалсан улстай харилцан адил байх зарчмыг баримтлахаар заасан. Тодруулж хэлбэл гадаадын иргэний эрхийг “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль”-иар тусгайлан зохицуулж, гадаадын 40 гаруй оронтой иргэд харилцан зорчих тухай гэрээ байгуулаад байна.

72. 2009 оны 12 дугаар сарын байдлаар Монгол Улсад 24654 гадаадын иргэн оршин суугаа бөгөөд энэ тооны ихэнх хувийг БНХАУ, БНСУ, ОХУ, АНУ, Япон, Украин зэрэг улсын иргэд эзэлж байна. Дээрх хуулийн дагуу гадаадын иргэдийн тоо Монгол Улсын харьяат хүн амын 1 хувь, үүний дотор нэг улсын иргэн 0.33 хувь хүртэл байна гэж зохицуулсан. Хэдийгээр Монгол Улсад хууль ёсоор оршин суугчид болон цагаач иргэдийн тоо манай улсын хүн амын дунд эзлэх хувь хэмжээ хуульд заасан хувь хэмжээний дотор, үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхөөргүй байгаа хэдий ч аль ч улсад түгээмэл хандлагатай байдаг хууль бусаар оршин суугч гадаадын иргэд манай улсад сүүлийн жилүүдэд нэлээдгүй хэмжээгээр нэмэгдэх болсон байна. Зохицуулалтын хувьд дээрх асуудлыг Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох “Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар” эрхлэн хариуцаж, ХЗДХЯ-ны харьяанд үйл ажиллагаагаа явуулж байна.

### **18. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх**

73. Монгол Улсын хэмжээнд нийтдээ 76.369 хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаагийн 46 хувийг эмэгтэйчүүд, 54 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Тэдний 33 хувь нь төрөлхийн, 67 орчим хувь нь олдмол шалтгааны улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

74. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, баталгаажуулах асуудлыг Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай, Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл мэндийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиуд түүнчлэн Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг



дэмжих Үндэсний хөтөлбөр зэрэг УИХ, Засгийн газраас гаргасан баримт бичгүүдийн хүрээнд зохицуулж буйгаас гадна УИХ “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай конвенц, түүний нэмэлт протокол”-ыг 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр тус тус соёрхон баталсан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг олон улсын хэмжээнд баталгаажуулахад чухал алхам боллоо.

75. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд албан байгууллагын нийт ажиллагсдын тодорхой хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд байх зохицуулалтыг хийлээ. Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд 2007 оны 8 дугаар сарын 3-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлтөөр 25, түүнээс дээш ажилтантай аж ахуй нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулах асуудлыг тусгав.

76. Засгийн газар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, хамгааллын асуудалд анхаарахаас гадна тэднийг хөгжүүлэх, эрхийг нь баталгаажуулах талаар тодорхой арга хэмжээ авч ирлээ. Тухайлбал 2006 оноос “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих Үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байна. Үүгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх замаар тэдний нийгмийн амьдралд оролцох оролцоог нь нэмэгдүүлэхэд чиглэгдэж буйгаараа нийгмийн халамж, хамгаалал, аж байдалд нь илүү анхаарсан нь өмнөх бодлого, хөтөлбөрүүдээс ялгаатай юм.

77. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай конвенц”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2008–2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ая тухтай амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх, эрхийг нь хүндэтгэсэн нийгмийн орчинг бүрдүүлж, тэднийг нийгмийн амьдралд бусад иргэдийн адил эрх тэгш оролцох нөхцөл, боломжийг хангасан орчны дэд бүтцийг бүрдүүлэх зорилтуудыг тус тус тусгасан билээ.

78. Түүнчлэн Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас хараагүй иргэдэд зориулсан брайль номыг хэвлэх, тараах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, тэдний нийгэм дэх оролцоог дээшлүүлэх талаар олон нийтэд чиглэсэн ухуулга, мэдээлэл, сурталчилгаа хийх чиглэлээр ТББ-уудтай хамтран ажиллах чиглэл баримталж байна.

### **19. Эмэгтэйчүүдийн эрх**

79. Эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хангах тухай төрийн бодлогыг 1924 оны анхдугаар Үндсэн хуулиас эхлэн одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “Үндсэн хууль” болон бусад хуулиудад тусган хэрэгжүүлж байна. 1996 онд УИХ-аас баталсан Монгол Улсын төрөөс баримтлах хүн амын бодлогод эмэгтэйчүүдийн эрх, хамгааллын асуудлыг тусгай бүлэг болгон авч үзсэн. Монгол Улсын Засгийн газраас “Эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулах Үндэсний хөтөлбөр” (1996–2002), “Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр” (2002–2015)-ийг батлан хэрэгжүүлж буй нь Монгол Улс жендэрийн асуудал, ялангуяа эмэгтэйчүүдийн эрхийн асуудалд ихээхэн анхаарч байгаагийн илрэл юм.

80. “Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр”-т эмэгтэйчүүдийн төлөөллийг улс төрийн удирдах болон шийдвэр гаргах түвшин, түүнчлэн төрийн албаны

удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх чиглэл тусгагдсан боловч өнөөдөр шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо бага байна. УИХ–д нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь 1992 онд 8 хувь байсан бол 2004 оны сонгуулиар 13.7 хувь, 2008 оны сонгуулиар 18.5 хувь болж өссөн нааштай үзүүлэлт гарлаа. 1992 оны сонгуулиар УИХ–д сонгогдсон нийт гишүүдийн дотор эмэгтэйчүүд 3.9 хувийг эзэлж байсан бол 1996 оны сонгуулиар 9.2 хувь, 2000 оны сонгуулиар 11.8 хувийн төлөөлөлтэй болж өсөх хандлагатай байсан ч 2004 оны сонгуулиар 6.6 хувь, 2008 оны сонгуулиар 3.9 хувь болж буурчээ. УИХ–ын 1992–2008 оны сонгуулийн дүнгээс харахад сонгогдсон эмэгтэй гишүүдийн нэр дэвшсэн эмэгтэй гишүүдтэй харьцуулахад эмэгтэй нэр дэвшигчийн эзлэх хувь байнга өссөн үзүүлэлт гарчээ.

81. Монгол Улс “Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц”–д 1981 онд нэгдэн орсон ба түүний нэмэлт протоколыг 2001 оны 12 дугаар сарын 14–ний өдөр соёрхон баталсан. Ийнхүү соёрхон баталснаар эмэгтэйчүүдийн эрх ашиг, эрэлт хэрэгцээг хангахад баримтлах шинэ үзэл санаа, шинэ хэм хэмжээг үндэсний хууль тогтоомжид тусгахыг эрмэлзэж байна. Тухайлбал Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг боловсронгуй болгох үүднээс “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх Үндэсний хөтөлбөр”–ийг Засгийн газрын тогтоолоор батлуулсан.

82. Хүүхэд, эмэгтэйчүүд бэлгийн зорилгоор ашиглагдах, хил дамжуулан худалдагдах байдал манай улсад төдийлөн хурцаар тавигдаж байгаагүй ч сүүлийн жилүүдэд монгол охид, хуурамч зарлалд хууртагдан гадаадад очиж, хууль бус орогнол, бичиг баримтын зөрчил, орлогогүй, хэл мэдэхгүйн улмаас тусламж авч чадахгүй байх зэргээс үүдэн бэлгийн хүчирхийлэл, доромжлолд өртөж, эрх нь зөрчигдөх болсон байна. Иймд Монгол Улс “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ–ын конвенц”–д 2008 онд нэгдэн орсон бөгөөд “Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах Үндэсний хөтөлбөр”–ийг батлан хэрэгжүүлж байна. Түүнчлэн Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд 2008 онд УИХ нэмэлт, өөрчлөлт оруулж, ашиг олох буюу мөлжих зорилгоор хүн худалдаалахдаа хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хууран мэхэлсэн, эмзэг байдлыг нь далимдуулсан, түүнчлэн бусдыг элсүүлсэн, тээвэрлэсэн, дамжуулсан, орогнуулсан, хүлээн авсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр болсон.

## **20. Хүнсний аюулгүй байдал**

83. Улс орны үндэсний аюулгүй байдлын нэг бүрэлдэхүүн хэсэг нь хүн амыг чанартай, аюулгүй, хүртээмжтэй хүнсээр хангах бөгөөд төрийн онцгой анхааралд байх асуудал юм. Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж заасан. Үндсэн хуульд зохистой, аюулгүй хоол хүнсээр хангагдах эрхийг тусгайлан заагаагүй хэдий ч энэ эрх нь эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн бүрэлдэхүүн хэсэг юм. Манай улсад хүнсний хангамж, аюулгүй байдалтай холбоотой харилцааг “Хүнсний тухай”, “Газрын тухай”, “Усны тухай”, “Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай”, “Улсын хилээр амьтан, ургамлын гаралтай

бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналтын тухай”, “Тариалангийн тухай”, “Ариун цэврийн тухай” зэрэг хуулиудаар зохицуулж байгаа бөгөөд эдгээр хуулиуд нь бүхэлдээ хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулахад чиглэгдэж байгаа юм.

84. Дэлхий дахинд хүнсний хомсдол бий болж, улс орнууд хүнсний баталгаат байдлын бодлого, хөтөлбөртөө өөрчлөлт оруулж байна. Монгол Улсын Засгийн газраас хүн амын хүнсний баталгаат байдлыг хангах чиглэлээр “Хүнсний хангамж аюулгүй байдал, хоол, тэжээл” хөтөлбөрийг 2001 оны 242 дугаар тогтоолоор батлан, хэрэгжүүлж байсан. Энэхүү хөтөлбөрийг Монгол Улсын хүнсний хангамжийн өнөөгийн байдал, хэтийн төлөв, дэлхийн дахинд буй болсон хүнсний хомсдол, үнийн өсөлт болон энэ талаар НҮБ, бусад олон улсын байгууллагаас гаргаж буй шийдвэр, зөвлөмжтэй уялдуулан шинэчлэн боловсруулж, Засгийн газрын 2009 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн 32 дугаар тогтоолоор “Хүнсний баталгаат байдал” үндэсний хөтөлбөрийг батлан, хэрэгжүүлж эхлээд байна.

85. 2006 онд хийсэн хоол тэжээлийн эрсдэлт хүчин зүйлийн судалгаагаар насанд хүрэгчдийн 4,9 хувь нь туранхай, 21,8 хувь нь илүүдэл жинтэй, 9,8 хувь нь таргалалттай байхад нийгмийн эмзэг бүлэг болох асран хамгаалах хүнгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өндөр настан, ядуу өрхийн хүн амд хүнсний хомсдол илүү их байгаа дүн гарсан байна. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас “Нийгмийн эмзэг бүлэгт хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх” дэд хөтөлбөрийг 2008 онд батлан Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 2009 оны эхнээс хэрэгжүүлж байна.

86. Монгол Улсын хүнсний баталгаат байдлыг сайжруулахын тулд хүнсний боловсруулах үйлдвэрийн хүч чадлыг нэмэгдүүлэх, тэдгээрт дотоодын хяналтын GMP, HACCP нэвтрүүлэх, баяжуулсан хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, цаашилбал хүн амын орлогын түвшинг нэмэгдүүлж тэдний хоол хүнсний хэрэглээний мэдлэгийг сайжруулах шаардлагатай байна.

#### **IV. НҮБ-ЫН ХҮНИЙ ЭРХИЙН ДЭЭД КОМИССАРЫН ГАЗРЫН ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН ТУСГАЙ ИЛТГЭГЧЭЭС ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ**

87. Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлнэ. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” хэмээн заасан. Энэхүү зохицуулалтын дагуу 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталсан “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц” Монгол Улсын үндэсний эрх зүйн системд чухал байр суурь эзэлдэг. Конвенцийн хэрэгжилтийн байдалтай танилцахаар НҮБ-ын Эрүүдэн шүүхийн тусгай илтгэгч Манфред Новак 2005 онд Монгол Улсад айлчилсан бөгөөд түүний айлчлалынхаа төгсгөлд гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар Монгол Улсын Их Хурал, Засгийн газар болон холбогдох төрийн байгууллагууд тодорхой үр дүнд хүрч байна.

88. 2007 онд ЭБШХ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд эрүүдэн шүүх аливаа үйлдлээс урьдчилан сэргийлэх, тийм нөхцөл байдалд хүргэхгүй байх үүднээс нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулсан. Мөн УИХ-аас баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 251.1-д эрүү шүүлт тулгах гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тусгаж өгсөн. Түүнчлэн хуулийн 251.2 болон 251.3-д энэ хэргийн улмаас хүний бие махбодид хүндэвтэр, хүнд гэмтэл, их хэмжээний хохирол учирсан, хохирогч нас барсан бол хүнд, онц хүнд гэмт хэрэгт тооцож ял оногдуулахаар заасан.

89. (Зөвлөмжийн С хэсгийн хүрээнд) ЭБШХ-ийн 59.5-д зааснаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч гагцхүү хойшлуулшгүй тохиолдолд сэжиглэгдсэн этгээдийг шууд баривчлах бөгөөд 24 цагийн дотор тогтоолыг прокурорт болон шүүхэд хүргүүлэхээр зохицуулсан бөгөөд ийнхүү хүргүүлснээс хойш 48 цагийн дотор баривчлах эсэхийг шийдвэрлэж, шүүгч нэн даруй захирамж гаргаж байхаар хуульчилсан. Баривчлах болон цагдан хорих эцсийн шийдвэрийг шүүгч гаргах болсонтой холбогдуулан шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хяналтад буюу түүний харьяа баривчлах, цагдан хорих төвд шилжүүлэхээр болсон. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид ЭБШХ-иар сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих эрх олгоогүй нь нэлээд ололттой зохицуулалт болж чадсан.

90. Цагдан хорих төвийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяанд шилжүүлсэнтэй холбогдуулан шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас уулзалт, байцаалтын байрыг барьж ашиглалтад оруулан цагдан хоригдож буй иргэдийг өмгөөлөгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчтэй уулзуулах нөхцөл боломжоор хангаж, аюулгүй байдал, хамгаалалтыг хариуцан, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан сэжигтэн, яллагдагчийн санал хүсэлтийг хүлээн авч холбогдох нэгжийн дарга нарт танилцуулан шийдвэрлүүлж, хариуг өгч байна.

91. (Зөвлөмжийн G хэсгийн хүрээнд) 2009 оны эхний 11 сарын байдлаар 7 албан хаагч үүргээ гүйцэтгэж байхдаа эрүүгийн хуулийн 99, 251 дүгээр зүйлд заасан гэмт хэргүүдэд шалгагдаж, эдгээр албан хаагчдад сахилгын арга хэмжээ авах, ажлаас халах, хугацааны цолыг хойшлуулах арга хэмжээнүүдийг авсан. Цагдаагийн байгууллага, албан хаагч эрүүдэн шүүсэн талаар хэн нэгнээс авсан мэдээллийн дагуу тодорхой арга хэмжээ явуулж, хяналт шалгалт хийн, эрх бүхий байгууллагад шилжүүлдэг бөгөөд энэ хооронд хохирогчийн өгсөн мэдээллийг нууцалдаг.

92. Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор зөвхөн сэжигтэн, яллагдагчийг зодох, доромжлох, дарамтлах хүрээнд биш баривчилсан шалтгаан болон эрхийг нь мэдэгдэх, өмгөөлөгч авах эрхээр нь хангах, эмнэлгийн үзлэг ба тусламж үзүүлэх, хүүхэд, эмэгтэйчүүдэд байцаан шийтгэх ажиллагаа явуулах үед баримтлах журам зөрчих зэрэг өргөн хүрээнд эрүүдэн шүүх ажиллагааг ойлгож, цагдаагийн байгууллагын албан хаагчдаас ийм зөрчил гаргуулахгүй байх, эрүүдэн шүүсэн үйлдлийг дотоодын хяналт шалгалт, иргэд, байгууллагын мэдээллийн дагуу шалгаж, хариуцлага хүлээлгэх, цаашид шийдвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна. Хууль хяналтын байгууллагын албан хаагч нараас үйлдсэн гэмт хэргийг УЕП-ын дэргэдэх Мөрдөн байцаах алба шалгадаг журамтай.

93. (Зөвлөмжийн О хэсгийн хүрээнд) Цагдаагийн байгууллагын харьяа албадуудын 2009–2010 оны хичээлийн жилийн сургалтын төлөвлөгөөнд цагдаагийн албанд орж ажиллахаар сурч байгаа сонсогчдод “Хүний эрх ба эрүү шүүлт” сэдэвт хичээлийг оруулахаар тусгаж, заагдсан хичээлүүдээр шалгалт авах, ном, сурах бичиг, сурталчилгааны материалаар хангах арга хэмжээг хэрэгжүүлж байна. Мөн Нийслэлийн Цагдаагийн газар (цаашид “НЦГ” гэх)–ын албан хаагчдын дунд Хүний эрхийн конвенциуд, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, Монгол Улсад Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөрийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, албаны сургалтынхаа хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгасны дагуу төрийн болон ТББ–уудтай хамтарсан сургалтыг явуулж, 11 төрлийн 150 ширхэг номыг НЦГ–ын номын фондод оруулсан нь цагдаагийн байгууллагад шинээр ажилд орж буй хүмүүс хүний эрхийн боловсролоо дээшлүүлэхэд ахиц болж байна.

94. (Зөвлөмжийн Р хэсгийн хүрээнд) Хүний эрхийн асуудлаарх сэдвийг Цагдаагийн академийн сургалтын төлөвлөгөөнд тусгаж өгсөн. Монгол Улс НҮБ–ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид нэгдэн орсноос хойш цагдаагийн байгууллага түүний үзэл санааг өөрийн үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж байна. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албаны удирдлагуудаас эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны үед эрүүдэн шүүсэн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авдаг, мөн прокурор хуулиар хяналт тавьдаг, ТББ хамтран ажилладаг тогтолцоо төлөвшиж байна. Нөгөөтэйгүүр эрүүдэн шүүхийн эсрэг сургалтуудад цагдаа, прокурор, шүүгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарыг өргөн хамруулж байна.

## **V. ХҮНИЙ ЭРХ – ТЭРГҮҮН АЧ ХОЛБОГДОЛ ӨГЧ БҮЙ АСУУДАЛ**

95. УИХ–аас 2003 онд баталсан “Монгол Улсад Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр” нь Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу боловсруулагдсан, хүний суурь эрхийг хангах, хамгаалах, үндэсний чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн 4 бүлэг 240 зүйл бүхий эрх зүйн тулгуур баримт бичиг юм. Уг хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх, биелэлтэд нь хяналт тавих эрх бүхий Хороо нь төрийн болон ТББ, нутгийн захиргааны байгууллагын төлөөлөл оролцсон орон тооны бус 30 гишүүнтэй. “Монгол Улсад Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр”–ийг хэрэгжүүлэх 2009–2010 оны төлөвлөгөөнд нийт 49 зорилтын хүрээнд 100 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгагдсан бөгөөд заалт тус бүрийг чанд хэрэгжүүлэхэд төр, засгийн болон орон нутгийн байгууллагаас гадна ТББ, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог эрс сайжруулах шаардлагатай гэж үздэг. Энэ зорилгоор 2009 онд “Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ТББ–ын оролцоо” сэдэвт чуулга, уулзалтыг зохион байгуулсан.

96. Монгол Улсад цаазаар авах ялыг бүрмөсөн халах эсэх асуудлын хувьд улс төрийн хүрээнд ч, олон нийтийн дунд ч өөр өөр үзэл хандлага байна. Хэдийгээр Монгол Улсын Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд цаазаар авах ялыг түдгэлзүүлэх санал дэвшүүлсэн хэдий ч ажил хэрэг болгохын тулд үндэсний хууль тогтоомжийн хүрээнд Эрүүгийн хууль зэрэг гол гол хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, олон улсын хэмжээнд гэвэл Иргэний болон улс төрийн эрхийн тухай пактын нэмэлт II протоколд нэгдэн орох

зэрэг асуудал гарах болно.

97. Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хэрэгжүүлэхэд уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, усны нөөцийн хомсдол, химийн бодисын зохисгүй хэрэглээ, аюултай хог хаягдал, агаар, хөрс болон усны бохирдол зэргээс үүдэлтэй байгалийн тэнцвэрт байдалд сөргөөр нөлөөлж буй нь тулгамдсан асуудал болж байна. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын судалгаанаас үзэхэд Улаанбаатар хот хамгийн их бохирдолтой байгаа бөгөөд үүний дийлэнх хэсгийг байнгын ажиллагаатай гурван цахилгаан станц, гэр хороололд хэрэглэгдэж буй 160000 орчим ердийн галлагаатай зуух, 120000 орчим тээврийн хэрэгсэл, 1500 орчим дунд болон бага оврын нам даралтын халаалтын зуух, нарийн шороо, ил хог хаягдлаас үүссэн их хэмжээний тоосонцор зэргээс агаарт 260000 гаруй тонн хорт бодис цацагдаж иргэдийг хордуулж байна. Агаарын бохирдлыг багасгах зорилгоор 2006 оноос жилд улсын болон орон нутгийн төсвөөс 2–3 тэрбум төгрөг зарцуулж утаагүй зуух, шахмал түлшний үйлдвэрийг дэмжих, орон сууцны барилгын асуудлыг нэмэгдүүлэх, “Ногоон хэрэм” хөтөлбөр хэрэгжүүлэх гэх мэт олон арга хэмжээ авсан ч үр дүн нь хангалтгүй байна.

98. 2007 оны сүүлчээр мэргэжлийн байгууллагаас хийсэн шинжилгээгээр Туул голын ус их хэмжээний бохирдолтой нь тогтоогджээ. Тухайлбал зарим үйлдвэрийн газрууд бохир усаа Туул гол руу асгадгаас болж 40 гаруй километр газарт 2–3 тонн загас үхсэн тохиолдол гарсан байна.

2000 оны байдлаар хүний зохисгүй үйл ажиллагааны улмаас Монгол Улсын нутаг дэвсгэрийн 33.8 хувийг эзлэх хээрийн бүсийн экосистемийн 11.6 хувь нь их, 2 хувь нь маш их доройтолд орсон байна. Энэ нь нэг талаас иргэдийн ухамсартай холбоотой боловч нөгөө талаас хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрүүдийн хэрэгжилт хангалтгүй, хөрөнгө зардал хүрэлцээгүй байгаатай холбоотой юм. Мөн гар аргаар алт олборлогчид алтны үндсэн ордыг зохих зөвшөөрөлгүй, аюултай химийн бодисын ашиглалтын горимыг мэдэхгүйгээр хэрэглэж өөрийгөө болон орчны хүмүүсийг хордуулж байна. Үүнээс болж гар аргаар алт олборлогчдын гэр бүлд тархины саажилттай, хэл яриа, сэтгэцийн эмгэгтэй, төрөлхийн суугаа, эрхтэн дутуу хүүхэд төрж байгаа нь химийн хорт бодис монгол хүний удмын санд аюултайгаар нөлөөлж буйг харуулж байна. Эдгээр бэрхшээлийг арилгах зөв бодлогыг тодорхойлж, хөрөнгө хүчийг төвлөрүүлэн ажиллах дэс дараатай арга хэмжээг хэрэгжүүлж эхлээд байна. Экологийн доройтлоос улбаатай хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахтай холбоотой санхүүжилтийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

99. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үйл ажиллагаанд энэ талаар үйл ажиллагаа явуулдаг болон тэдний оролцооны байгууллагуудын хүчин чармайлт ихээхэн чухал байгаа бөгөөд цаашид хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, эрх чөлөөгөө эдлэх тэгш боломжийг бий болгохын тулд тэдний тусгай хэрэгцээнд нийцсэн хууль, эрх зүй, нийгэм, улс төр, эдийн засгийн болон дэд бүтэц, сэтгэл зүйн орчинг сайжруулах, шинэ түвшинд гаргах зайлшгүй шаардлага, хэрэгцээ байсаар байна.

100. Манай улсад гэрийн ажил, үр хүүхдээ асрах, хүмүүжүүлэх нь зөвхөн гэр бүлийн эмэгтэй гишүүний үүрэг гэсэн хэвшмэл ойлголт давамгайлсан хэвээр байгаагийн зэрэгцээ ажлын байр дахь бэлгийн дарамт далд хэлбэрээр байсаар байна. Түүнчлэн

хүйсээр ангилсан тоо мэдээлэл хэт ерөнхий, бодит мэдээлэл хангалтгүй байгаагаас жендэрийн тэгш байдлыг хангах эцсийн үр дүнг бодитой тооцоход хүндрэлтэй байна. Ядуурал, ажилгүйдэл зэрэг нийгмийн сөрөг үзэгдлийн улмаас эмэгтэйчүүд гэр бүлийн хүчирхийлэл, хил дамнасан хүний наймаанд өртөх, гэр бүл салах явдал түгээмэл болж байна. Мөн хуулийн хэрэгжилт болон хүмүүсийн эрхээ хамгаалах чадвар сул байгаагаас эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалуулах, аюулгүй орчинд тайван амьдрах эрх зөрчигдөх явдал амьдрал дээр олонтаа тохиолдож байна. Цаашид эрүүл мэнд, боловсрол зэрэг эмэгтэйчүүд давамгайлсан салбаруудад жендэрийн зохистой харьцааг бий болгох шаардлагатай байна.

101. Америкийн Нэгдсэн Улсын Азийн сангийн захиалгаар Максима судалгааны төвийн явуулсан судалгаагаар цагдаагийн байгууллагад эрс шинэчлэл хийхийг олон нийт, цагдаагийн нийт бие бүрэлдэхүүн дээд, дунд, доод бүх шатанд хүссэн байна. Иймд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулж, бүтэц зохион байгуулалтыг бэхжүүлэх талаар судалгаанд оролцогчид 20 гаруй санал дэвшүүлснийг анхаарч үзэх шаардлагатай. Судалгаанд хамрагдсан иргэд цагдаа дахь сөрөг үзэгдэл нь “алаг үзэх” явдал болсон гэж үзсэн байна. Мөн цагдаагийн удирдах ажилтнуудын албан хаагчдынхаа ажил үүргээ явуулахтай холбоотой хараат бус байдалд нөлөөлдөг, танил тал, мөнгөтэй хүнд үйлчилдэг гэж дүгнэсэнд Засгийн газар онцгой анхаарал хандуулж, тодорхой арга хэмжээ авах болно.

## **VI. ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ**

102. Монгол Улс Ээлжит нэгдсэн хэлэлцүүлгийн ажиллагаанд идэвхтэй оролцох бөгөөд Хүний эрхийн Зөвлөлөөс гаргах санал, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд онцлон анхаарна. Мөн хүний эрхийг хамгаалах, дэмжих чиглэлээр дэлхийн бусад улс орон, НҮБ болон түүний системийн холбогдох байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэхэд хүчин чармайлт гарган ажиллах болно.

## 9.2 МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТАЛААРХ ҮНДЭСНИЙ ИЛТГЭЛИЙГ ХЭЛЭЛЦЭЭД НҮБ–ЫН ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨВЛӨЛӨӨС ӨГСӨН ЗӨВЛӨМЖ

### Удиртгал

1. Хүний эрхийн зөвлөлийн 5/1 тоот шийдвэрээр байгуулагдсан, Хүний эрхийн төлөв байдлын үндэсний ээлжит хэлэлцүүлгийн Ажлын хэсэг нь 2010 оны 11 дүгээр сарын 1–ээс 12–ны хооронд 9 дүгээр хуралдаанаа зохион байгууллаа. 2010 оны 11 дүгээр сарын 2–ны өдрийн 3 дугаар хурлаар Монгол Улсын дүгнэлтийг хэлэлцэв. Монголын талын төлөөлөгчдийг Монгол Улсын Гадаад Харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Цогтбаатар тэргүүлэв. 2010 оны 11 дүгээр сарын 4–ний өдрийн 5 дугаар хурлаар Ажлын хэсэг Монголын тайланг баталлаа.

2. 2010 оны 6 дугаар сарын 21–ний өдөр Хүний эрхийн Зөвлөл Монгол Улсын дүгнэлтийг хэлэлцэх асуудлыг хөнгөвчлөх зорилгоор Габон, Кыргызстан, Швейцар улсыг илтгэгчдээр сонгов.

3. 5/1 тоот шийдвэрийн хавсралтын 15 дугаар хэсгийн дагуу Монгол Улсын дүгнэлтийг хэлэлцүүлэхтэй холбогдуулан дараах баримт бичгүүдийг боловсруулав. Үүнд:

(a) 15(a) заалтын дагуу ирүүлсэн үндэсний тайлан, танилцуулга (HRC/WG.6/9/MNG/1);

(b) 15(b) заалтын дагуу НҮБ–ын Хүний Эрхийн Дээд Комиссарын ажлын албанаас бэлтгэсэн эмхтгэл (HRC/WG.6/9/MNG/2);

(c) 15(c) заалтын дагуу бэлтгэсэн НҮБ–ын Хүний Эрхийн Дээд Комиссарын ажлын албанаас бэлтгэсэн товч дүгнэлт (HRC/WG.6/9/MNG/3);

4. Бүгд Найрамдах Чех Улс, Дани Улс, Нидерланд Улс, Словени Улс, Швед Улс, Швейцар Улс, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсаас урьдчилан бэлтгэж ирүүлсэн асуултуудыг илтгэгчдээр дамжуулан Монгол Улсад хүргүүлсэн.

#### I. Хэлэлцүүлгийн явцын тухай товч мэдээлэл

5. Харилцан ярианы явцад 43 төлөөлөгч мэдэгдэл хийв. Харилцан ярианы явцад гарсан зөвлөмжүүдийг энэхүү тайлангийн II дахь хэсэгт багтаасан болно.

#### A. Хэлэлцсэн Улсын илтгэл

6. Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Цогтбаатар тэргүүтэй Монголын төлөөлөгчид 3 дугаар хурлаар үндэсний илтгэлээ эхлүүлэхдээ Монгол Улсын Засгийн газар хүний эрхийн төлөв байдлын үндэсний ээлжит хэлэлцүүлэг нь Монгол Улсын хүний эрхийн салбарт хуримтлуулсан туршлагыг бусад улстай хуваалцах, мөн олон улсын шилдэг туршлагаас суралцах ховор боломж хэмээн үзэж буйг онцолсон юм. Монгол Улс сүүлийн 20 жилийн хугацаанд хүний эрхийг хангах, институтжүүлэхэд ихээхэн хүчин чармайлт гаргасаар ирсэн хэдий ч цаашид сайжруулах зүйлс буйг Монгол Улсын Засгийн газар онцлов. Мөн төлөөлөгчид Монгол Улсын Засгийн газар



хэлэлцүүлгийн үйл явцад идэвхтэй оролцон, Зөвлөлөөс гаргасан санал, зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд чармайлт гаргах болохыг илэрхийллээ.

7. 1992 оны МУ–ын Үндсэн хуулиар хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан бөгөөд Монгол Улс иргэдийнхээ эрх, эрх чөлөөг хамгаалах, тэдгээр эрх, эрх чөлөөг бодитой эдлүүлэхэд улс төрийн болон хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чухал ач холбогдол өгч ирснийг онцлов. Тухайлбал Монгол Улс хүний эрхийн үндсэн баримт бичгүүдэд нэгдэн орсон, хүний эрхийн үндэсний институтуудыг дэмжихэд ихээхэн анхаарсан, УИХ–аас 2003 онд “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”–ийг баталсан, мөн энэхүү хөтөлбөрийн өдөр тутмын хэрэгжилтийг зохицуулах ажлыг хариуцсан Үндэсний хөтөлбөрийн хороог байгуулсан зэргийг дурдаж болно.

8. Үндэсний илтгэлийг Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар батлуулсан. Уг Ажлын хэсэг нь Хүний эрхийн Үндэсний Комисс, холбогдох шинжээч, мэргэжилтнүүд болон төрийн бус байгууллагуудтай олон удаагийн зөвлөгөөн хийжээ. Үүний зэрэгцээ 2010 оны 2 дугаар сард МУ–ын Засгийн газар, НҮБ–ын Хөгжлийн хөтөлбөр болон иргэний нийгмийн байгууллагууд хооронд гурван талт зөвлөгөөн зохион байгуулагдсан.

9. Монгол Улс иргэний болон улс төрийн эрхийг анхааран хамгаалахын зэрэгцээ эдийн засаг, нийгэм, соёлын эрхүүдийг хамгаалах, дэмжих чиглэлээр ажилласан. Түүнчлэн Засгийн газар хүн амын дундаж орлогоос доош сарын орлоготой иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг дэмжихэд анхаарч ажилласан болно. Үндэсний цөөнхийн эрхийг хамгаалах нь Засгийн газрын нэг тэргүүлэх зорилго бөгөөд энэ хүрээнд үл алагчилах бодлого, үндэсний цөөнхийн эрхийг хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлж байна.

10. УИХ–аас 2010 оны 12 дугаар сарын 7–ны өдөр Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг баталсан бөгөөд энэхүү бие даасан Комисс нь 2001 оны 2 дугаар сард үйл ажиллагаагаа эхэлсэн.

11. Монгол Улс цаазаар авах ялыг de jure хуульчилсан ба 2010 онд Монгол Улсын Ерөнхийлөгч цаазаар авах ялыг түдгэлзүүлж хориг (moratorium) тавьснаа зарлан, энэ нь цаашид уг ялыг халахад эхний алхам болох учиртайг тэмдэглэсэн. Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын хоёр дугаар нэмэлт протоколд нэгдэн орох асуудлыг УИХ–аар хэлэлцэж байна.

12. Монгол Улсын Засгийн газар эмэгтэйчүүдийн болон хүүхдийн эрхийг хамгаалах асуудлыг анхааралдаа авч зохих үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. 2010 онд МУ–ын Засгийн газар, БНХАУ–ын Макаогийн ЗСОБ–ийн Засгийн газар хооронд “Хүн худалдаалахтай тэмцэх талаар хамтран ажиллах хэлэлцээр”–т гарын үсэг зурсан ба энэхүү хэлэлцээр нь хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, мөн тийм гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах, буцаан авчрах талаар хоёр талын үр дүнтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх үндсийг бүрдүүлнэ хэмээн үзсэн.

13. Дэлхийн дулаарал болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй мөс хайлах, гадаргуу дээрх ус ширгэх, ургац буурах, ус эрдэсжих, хөрсний элэгдэл, цөлжилт зэрэг хүчин зүйлс амьдрах орчин нөхцөлд таагүй нөлөө үзүүлж байна. 2010 онд Цөлжилттэй тэмцэх хөтөлбөр болон Усны хөтөлбөр батлагдсан. Зуд, цасан болон шороон шуурга зэрэг

байгалийн гамшигт үзэгдлүүд малчин айл, өрхүүд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхэд сөргөөр нөлөөлж байна. Иймд малчдын амьдрах нөхцлийг сайжруулах, тэдний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулах зорилгоор “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ыг 2009 онд УИХ-аас батлан гаргасан.

14. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг бүх иргэдэд аливаа алагчлалгүйгээр үзүүлдэг. Монгол Улсын Засгийн газар 2008–2012 оны Үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан ба үүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах зорилтуудыг дэвшүүлэхийн зэрэгцээ хувийн даатгалын тогтолцоог нэвтрүүлсэн юм.

15. УИХ 2005 онд баталсан Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудад бүх шатны боловсролын түвшинд жендэрийн тэгш бус байдлыг арилгах, хөдөө аж ахуйн бус салбарт эмэгтэй ажилчдын тоог 50 хүртэлх хувиар нэмэгдүүлэх, 2015 он хүртэл УИХ дахь эмэгтэй гишүүдийн тоог 30 хувьд хүргэх зэрэг жендэрийн тэгш байдлын үндсэн зорилтуудыг тусгасан. Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо өнөөг хүртэл хангалтгүй байна. Эмэгтэй нэр дэвшигчдийн тоо тогтвортой нэмэгдэж байгаа хэдий ч УИХ дахь тэдний эзлэх хувь буурсаар байна. Эмэгтэй нэр дэвшигчдийн тоог нэмэгдүүлэх нь зүйтэй хэмээн Монгол Улс үзэж байна. УИХ Засгийн газраас санаачилсан Жендэрийн тэгш байдлын тухай хуулийн төслийг хэлэлцэхээр төлөвлөөд байна.

16. Засгийн газар Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай конвенц, түүний нэмэлт протоколыг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж ирсэн бөгөөд 2008–2012 оны Үйл ажиллагааны хөтөлбөртөө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан хэвийн дэд бүтцийг бий болгох, мөн амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилтуудыг дэвшүүлсэн. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам хараагүй иргэдэд зориулсан номыг хэвлэх, түгээх, мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог бэхжүүлэх ач холбогдлыг олон нийтэд таниулах, энэ тухай иргэдийн боловсролыг дээшлүүлэх талаар төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллаж байна.

17. Төлөөлөгчид ядуурал, ажилгүйдэл, хүнсний аюулгүй байдал, хотын агаарын бохирдол зэрэг олон тулгамдаж буй асуудлыг тэмдэглэхийн зэрэгцээ Засгийн газар өөрийн иргэд болон бусад улсын туслалцаатайгаар эдгээр бэрхшээлийг даван туулах улс төрийн хүсэл зоригтой байгааг мэдэгдэв. Засгийн газар хүний эрхийг хангах явдал болон эдийн засгийн өсөлтийг дэмжих асуудлыг тэнцвэртэйгээр уялдуулах, уул, уурхайгаас гарч буй баялгийг тэгш байдлаар, үр дүнтэй ашиглах талаар чармайлт гаргаж байна.

18. Гэрээний талуудад үе шатны илтгэл, тайланг тогтмол хүргүүлэхийн зэрэгцээ түүний мөрөөр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх мэдээллийг тусгай илтгэгчдэд мөн хүргүүлж ажиллаж байгааг тэмдэглэн, цаашид тайлангийн чанарыг сайжруулахад анхаарах шаардлага буйг хүлээн зөвшөөрөв.

19. Төлөөлөгчид Засгийн газар энэхүү үндэсний ээлжит хэлэлцүүлгийн зорилгод гагцхүү бүх улс орон, төрийн бус байгууллагуудын идэвхтэй оролцоо, бүтээлч харилцааны дүнд хүрнэ гэж үзэж буйг тэмдэглэхийн зэрэгцээ Монгол Улсад хүний эрхийг хамгаалах, дэмжихэд бүх түншүүдтэй хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийллээ.

20. Цаазаар авах ялыг халах асуудлаарх урьдчилсан асуултуудын хүрээнд төлөөлөгчид Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар нэмэлт протоколд нэгдэн орох асуудал Засгийн газраар дэмжигдсэн бөгөөд УИХ-ын холбогдох

байнгын хороо уг асуудлыг хэлэлцэж байгаа талаар мэдээлэв. Хэрэв УИХ парламент протоколыг соёрхон баталсан тохиолдолд цаазаар авах ялын талаар зохицуулсан бүх хууль тогтоомж болон Төрийн нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд боловсруулах тухай мэдэгдэв.

21. Урьдчилан өгөгдсөн асуултын хүрээнд төлөөлөгчид 2008 онд Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр “эрүү шүүлт тулгах гэмт хэрэг”-ийн тухай тодорхойлолтыг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид нийцүүлэн өөрчилж тусгасныг дурдлаа. Түүнчлэн энэхүү нэмэлт, өөрчлөлтийн дүнд мөрдөн шалгах ажиллагаанд оролцож буй албан тушаалтан хэрэг хүлээлгэх, мэдээлэл олж авахын тулд сэжигтнийг эрүүдэн шүүсэн, харгис хэрцгий хандсан, хүнлэг бус, доромжилсон арга хэрэглэсэн бол Эрүүгийн хуулийн дагуу шийтгэл хүлээх юм. Ажлын хэсэг энэхүү конвенцийн нэмэлт протоколыг соёрхон батлах талаар судалж байна.

22. Төлөөлөгчид ЛГБТ хүмүүсийг бэлгийн чиг хандлагаар нь алагчилсан тохиолдол бүртгэгдээгүйг тэмдэглэлээ. Прокурорын байгууллагаас энэ асуудлаар тогтмол хяналт шалгалт хийдэг бөгөөд иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээж авах зорилгоор сар бүр нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулдаг. Сэжигтэн, яллагдагчийг байцаах явцад өмгөөлөгчийн оролцоог хангаж ажилладаг. Засгийн газар ЛГБТ хүмүүсийн талаар судалгаа явуулж, тэдний хүсэлт, шаардлагыг тодруулахаар төлөвлөсөн бөгөөд энэ нь шаардлагатай хууль, эрх зүйн өөрчлөлтийг хийх боломжийг бүрдүүлнэ. Түүнчлэн ЛГБТ хүмүүсийн холбоо бүртгэгдсэн байна.

23. Цагдан хорих хугацааны тухайд төлөөлөгчид Эрүүгийн байцаан шийтгэх хуульд 2007 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр цагдан хорих хугацааг багасгасан бөгөөд ингэхдээ гэмт хэргийн нөхцөл байдлаас хамааран уг хугацааг 1 сараас хамгийн ихдээ 24 сар хүртэл байхаар тогтоосон тухай мэдээлэв.

24. Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу ажил олгогч тухайн эрхлэх ажил, үүргийн онцлогтой холбоогүй бол ажилтны хувийн амьдрал, гэрлэлтийн байдал, бэлгийн чиг хандлага болон жирэмсэн эсэх талаар асууж болохгүй. ЛГБТ хүмүүсийг бэлгийн чиг хандлагаас нь шалтгаалж ажлаас чөлөөлсөн тохиолдол, мэдээ баримт байхгүй. Түүнчлэн холбогдох хууль тогтоомжоор хүмүүсийг бэлгийн чиг хандлагаар нь алагчлахыг хориглосон.

25. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам тэнэмэл хүүхдүүдэд туслах, мөн хөгжим, соёлын аргаар нийгэмшүүлэх бодлогыг хэрэгжүүлсэн. УИХ-д өргөн барьсан Нийгмийн халамжийн тухай хуулиар орлого багатай ядуу өрх болон хүүхдүүдэд бэлэн мөнгөний тусламж олгох халамжийн тогтолцоог бий болгосон.

## **Б. Дүгнэлтийн явц дахь харилцан ярилцлага ба Монгол Улсын өгсөн хариултууд**

26. Бусад орны төлөөлөгчид Монгол Улсад үндэсний ээлжит хэлэлцүүлгийн механизмтай хамтарч ажиллаж байгаад талархсанаа илэрхийлж, үндэсний илтгэлээ бэлтгэх явцад иргэний нийгэмтэй бүтээлч хамтын ажиллагааг өрнүүлсэн болон мөн хэлэлцүүлгийн үеэр үндэсний илтгэлийг өргөн хүрээтэй танилцуулсныг сайшаав.

27. **Алжир Улс** Хүний эрхийн Үндэсний Комисс, Үндэсний хөтөлбөр гэх мэт хүний эрхийг хамгаалах олон талт механизмыг бүрдүүлснийг сайшаав. Монгол Улс нь хүний

эрхийн олон улсын ихэнх баримт бичгүүдэд нэгдэн орсон, мөн цаазаар авах ялыг түдгэлзүүлснийг онцлов. Алжир Улс санал, зөвлөмжүүд гаргав.

28. **Морокко Улс.** Монгол Улсын хөгжлийн эерэг үзүүлэлтүүд болон ардчилсан улс байгуулахад гаргасан Засгийн газрын хичээл зүтгэлийг онцлов. Цөөнхийн эрхийг хамгаалах чиглэлээр ажиллаж, хууль зүйн туслалцаа үзүүлэх төвүүдийг байгуулсныг сайшаан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалах, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль болон Жендэрийн тэгш байдлын Хөтөлбөр баталсныг талархан хүлээн авав. Түүнчлэн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн салбарт гаргасан хүчин чармайлт болоод сонгуулийн тогтолцоонд хийсэн шинэтгэлийг тэмдэглэв. Монгол Улс дахь ардчиллын үйл явцыг дэмжихэд олон улсын хамтын нийгэмлэгийг дахин уриаллаа.

29. **ОХУ.** Хүний эрхийн үндсэн конвенцуудад нэгдэн орсон, эрүүл мэнд, суурь боловсролыг үнэ төлбөргүй олгож байгаа, түүнчлэн Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр батлан хэрэгжүүлж, хүний эрхийн үндэсний механизмуудыг дэмжин ажиллаж буйг сайшаав. Цаазын ялын гүйцэтгэлийг түдгэлзүүлсэн, мөн үндэсний илтгэл, түүний танилцуулгын үеэр хэлсэн үгэндээ өөрийн улсад хүний эрхийг хамгаалахад тулгарч буй хүндрэл бэрхшээлийг гарган тавьсныг онцлон тэмдэглэж байв. ОХУ зөвлөмж гаргав.

30. **Индонез Улс.** Сүүлийн жилүүдэд Хүний эрхийн Үндэсний Комисс байгуулж, Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр баталсныг таатайгаар хүлээн авав. Түүнчлэн эмэгтэйчүүд болон хүүхдийн эрхийг дэмжих, хүйсийн тэгш эрхийг хангах талаар гаргасан хүчин чармайлт, ахиц дэвшлийг онцлон тэмдэглэв. Хэдий тийм боловч ядуурал нь хүн амын хүний үндсэн эрхийг хангахад улс оронд гол саад бэрхшээл учруулж буйг дурдав. Индонези Улс санал, зөвлөмжүүд гаргав.

31. **Франц Улс.** Цаазаар авах ялыг түдгэлзүүлж, улмаар Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын 2 дугаар нэмэлт протоколд нэгдэн орох асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлж буйг талархан хүлээж авав. Хүний эрхийн олон улсын томоохон баримт бичгүүдэд нэгдэн орсныг сайшаахын хамтаар Хүчээр алга болгохын эсрэг Конвенцыг соёрхон батлаагүй байгааг тайлбарлахыг хүсэв. Мөн цагдаагийн албан хаагчидтай холбоотой эрүүдэн шүүх гэмт хэргийн талаар дурдаж байв. Франц Улс санал, зөвлөмжүүд гаргав.

32. **Польш Улс.** Хүний эрхийн институтуудыг байгуулахад гаргасан ахиц, дэвшил, мөн хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг талархан хүлээж авав. Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах хороо болон Хүүхдийн эрхийн хорооны мэдэгдсэнээр хүн худалдаалах гэмт хэрэг, эмэгтэйчүүд, охидын бэлгийн мөлжлөг ихэсч, харин хүчирхийлэл үйлдэгчдэд эрүүгийн хариуцлага оногдуулах, шийтгэх асуудал хангалтгүй байгааг дурдаж, холбогдох шалтгаан нөхцлийг тодруулах чиглэлээр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн талаар тайлбар хүсэв. Польш Улс санал, зөвлөмжүүд өгөв.

33. **Австрали Улс.** Монгол Улс ардчиллыг хөгжүүлэх тал дээр тууштай зогсож, Хүний эрхийн Үндэсний Комисс байгуулсан ба түүний статус А үнэлгээгээр магадлан итгэмжлэгдсэн явдалд баяр хүргэв. Цаашид Комиссын үйл ажиллагааны цар хүрээг нийгмийн бүхий л давхарга, алслагдсан орон нутагт хүргэх чиглэлээр анхаарахыг зөвлөмж болгов. Мөн Монгол Улс цаазаар авах ялыг түдгэлзүүлснийг сайшаан, түүнийг

үндэсний хууль тогтоомжоор халахыг уриалав. Австрали Улс санал, зөвлөмжүүд гаргав.

34. **Мексик Улс.** Хүний эрхийн салбарт хийгдсэн ахиц, дэвшлийг тэмдэглэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон боловсролыг бүх нийтээр хүртэх, хүнсний аюулгүй байдлыг хангах талаар явуулсан үйл ажиллагааг онцлов. Мөн цаазаар авах ялыг түдгэлзүүлснийг талархан хүлээж авав. Мексик Улс санал, зөвлөмжүүд гаргав.

35. **Канад Улс.** Цаазаар авах ялыг түдгэлзүүлсэн ч үндэсний хууль тогтоомжид уг ял байсаар буйг онцлов. Хүний наймаа, цагдаагийн байгууллага дахь баривчлагдсан болон цагдан хоригдсон этгээдүүдэд хүч хэрэглэх явдал, төрийн албан дахь авлигын асуудал гарсаар буйг сануулж байв. Канад Улс санал, зөвлөмжүүд гаргав.

36. **Герман Улс.** Хүний эрхийн Үндэсний Комисс байгуулсан явдлыг сайшаав. Мөн цаазаар авах ялыг түдгэлзүүлснийг сайшаан, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пактын нэмэлт протоколыг соёрхон баталсныг онцлон тэмдэглэв. Эрүүдэн шүүхийн асуудлаарх Тусгай илтгэгчийн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар анхаарч, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 22 дугаар зүйлийн дагуу мэдэгдэл гаргах боломжийг судлахыг уриалав. Герман Улс санал, зөвлөмжүүд гаргав.

37. **Малайз Улс.** Олон улсын хүний эрхийн үүрэг амлалтаа саад бэрхшээлээс үл хамааран биелүүлснийг тэмдэглэн, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах, боловсрол эзэмших эрхийг дэмжих, хүнсний аюулгүй байдлыг хангах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг сайшаав. Мөн олон улсын хүний эрхийн хяналт–шинжилгээний механизмуудтай хамтран ажиллаж буйг дэмжлээ. Малайз Улс санал, зөвлөмжүүд гаргав.

38. **Унгар Улс.** Жендэрийн тэгш байдлын тухай хуулийн төсөл боловсруулж, түүнд шуудаар болон шууд бусаар алагчлах тухай тодорхойлолт оруулсныг талархан тэмдэглэв. Хүний эрхийн олон гэрээг соёрхон баталсныг сайшаахын зэрэгцээ хүний эрхийг үндэсний түвшинд цаашид хамгаалан бэхжүүлэх шаардлагатайг онцоллоо. Эрүүгийн хуулийн 44 дүгээр зүйлийн 1 дэх заалт нь хууль хяналтын байгууллагын ажилтнууд ял шийтгэлээс чөлөөлөгдөхөд хүргэж болзошгүйг сануулав. Унгар Улс санал, зөвлөмжүүд гаргав.

39. **Куба Улс.** Үндсэн хуулиар эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулж, 30 гаруй холбогдох хууль, эрх зүйн акт баталсныг тэмдэглэв. МУ-ын Засгийн газар эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг аль болох олон хүнд хүргэх талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлжээ. Алагчилах явдал, ялангуяа хүйсээр алагчлахтай тэмцэх, устгах чиглэлээр ажилласан, мөн Хүүхдийн хөгжлийн Үндэсний стратеги, Хүүхдийн хөгжил, хамгааллыг бэхжүүлэх үндэсний Хөтөлбөр баталсан зэрэг бусад санаачилгыг цохон тэмдэглэв. Куба Улс санал, зөвлөмжүүд гаргав.

40. **Хятад Улс.** Хүний эрхийг хамгаалах, дэмжих асуудлыг үндэсний хөгжлийн стратегид тусгасан 2008–2012 оны Үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлж буй, мөн шаардлагатай хууль тогтоомж батлах, түүнчлэн арга хэмжээ авах замаар нийгмийн эмзэг бүлгийн нийгмийн хамгааллын асуудалд онцгойлон анхаарч буйд талархал илэрхийлэв. Ядуурлыг бууруулах, хүрээлэн буй орчны хамгаалал болон хүйсээр алагчлахтай тэмцэх зэрэг асуудал, тулгарч буй бэрхшээлийг дурдаж, Монгол Улс үүнд нээлттэй бөгөөд хариуцлагатай байр суурь баримталж буйг сайшаав. Хятад Улс санал, зөвлөмжүүд өгөв.

41. **Словак Улс.** Хүний эрхийн олон улсын үндсэн баримт бичгүүдэд нэгдэн орсон,

мөн тусгай илтгэгчидтэй байнга хамтран ажиллаж буйг сайшаан, цаазаар авах ялыг түдгэлзүүлснийг талархан хүлээн авав. Эмэгтэйчүүдийн үүрэг, хариуцлагын талаарх хэвшмэл ойлголтын тухайд хүний эрхийн хяналт–шинжилгээний механизмаар дамжин илэрсэн асуудлуудыг мөн онцоллоо. “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц”–ийг соёрхон баталсныг сайшаав. Словак Улс санал, зөвлөмжүүд гаргав.

42. **Бразил Улс.** Мянганы хөгжлийн зорилтууд, ялангуяа жендэрийн тэгш байдалд анхаарч ажиллаж буйг сайшаав. Ажилгүйдэл ба ядуурлын түвшин өндөр, орон гэргүй хүмүүс болон ажил хийж буй хүүхдүүдийн тоо өсч байгаа зэрэг нь Засгийн газрын өмнө тулгарч буй шийдвэрлэх гол асуудлууд болохыг тэмдэглэв. Үндэсний ээлжит хэлэлцүүлгийн баримт бичгүүдэд эмэгтэйчүүдийг алагчлах явдал байсаар байгаа ба мөн хүүхдэд бие махбодийн шийтгэл оногдуулж буй тухай дурдагдсаныг онцлов. Бразил Улс санал, зөвлөмжүүд гаргав.

43. Цаазаар авах ялын гүйцэтгэлд моратори зарласныг онцлон тэмдэглэж, түүнийг de jure халах зорилгоор Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт II протоколд гарын үсэг зурах буюу түүнийг соёрхон батлах төлөвлөгөөг сайшаав. Мөн ЛГБТ хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлээр ямар арга хэмжээ авч буй, нөгөөтэйгүүр тэд эрхээ бүрэн хэмжээнд эдэлж чадаж буй талаар сонирхож байв. Швед Улс санал, зөвлөмжүүд гаргав.

44. **Норвеги Улс.** Хүний эрхийн олон улсын гол баримт бичгүүдэд нэгдэн орсон, түүнчлэн хүний эрхийн Тусгай илтгэгчдийг өөрийн оронд ирж ажиллуулахад бэлэн бүйд талархал илэрхийлэв. Цаазаар авах ялыг түдгэлзүүлснийг сайшааж, сүүлийн үед үндсэрхэг үзлийн улмаас нийгмийн тодорхой бүлэг, тухайлбал ЛГБТ хүмүүсийг алагчлах, тэдний эрхийг зөрчиж буй хэрэг тохиолдол гарч буйг онцлов. Дүрвэгсэдийн эрх зүйн байдлын тухай 1951 оны конвенц, түүний 1967 оны нэмэлт протоколд тус тус нэгдэн орох боломжийг судлахыг уриалав. Норвеги Улс санал, зөвлөмжүүд гаргав.

45. **Азербайжан Улс.** 2010 оны 4 дүгээр сард Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протоколыг соёрхон баталсныг сайшаан тэмдэглэв. Мөн Эрүүдэн шүүхийн асуудлаарх Тусгай илтгэгч зэрэг институтуудтай хамтын ажиллагааг нэмэгдүүлж, улмаар Эрүүгийн хуульдаа эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаар тусгасныг тэмдэглэв. Монгол Улс цаг уурын өөрчлөлттэй холбоотой гамшигтай тулгарч буйг дурдлаа. Эмэгтэйчүүдийн эрхийг бэхжүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг талархан хүлээж авахын хажуугаар хүний наймаа газар авч байгааг мөн хөндөв. Азербайджан Улс санал, зөвлөмжүүд гаргав.

46. **Их Британи Улс.** Монгол Улс гэрээний байгууллагуудад илтгэлээ хүргүүлж буйг сайшаав. Эрүүдэн шүүх тухай ойлголтыг бүрэн агуулгаар нь тодорхойлох талаар анхаарахыг хүсэлт болгов. Засаглалын ил тод байдлын талаар тус улсаас гаргаж буй зөвлөмжийг хэрэгжүүлэхэд Монгол Улс анхаарал хандуулна гэдэгт итгэлтэй буйгаа дурдав. Цаазаар авах ялыг халах болон бэлгийн чиг хандлагаар алагчлахын эсрэг ямар хууль тогтоомж гаргах талаар асууж тодруулав. Их Британи Улс санал, зөвлөмжүүд гаргав.

47. Төлөөлөгчид Монгол Улс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 2 дугаар нэмэлт протоколд нэгдэн орох асуудлыг Улсын Их Хурлын Аюулгүй

байдал, гадаад бодлогын байнгын хороогоор хэлэлцэж буй бөгөөд эерэг үр дүн хүлээж буйгаа мэдэгдэв.

48. Төлөөлөгчид Монгол Улс НҮБ-ын гэрээний хэрэгжилт хариуцсан байгууллагуудад тайлан хүргүүлэхдээ чанарын тал дээр ихээхэн анхаардаг боловч тайлагнах явцад цаг хугацаа шахуу байх, үнэн, бодит мэдээлэл, тэдгээрийн чанарын асуудал гол бэрхшээл дагуулдгийг тэмдэглэв. Монгол Улсын Засгийн газар саяхан гэрээний байгууллагуудад үйл ажиллагаагаа цаг хугацаанд нь тайлагнах журмыг баталсан.

49. Төлөөлөгчид МУ-ын Засгийн газар хүн худалдаалахтай тэмцэх асуудал тэргүүлэх ач холбогдолтойг дахин тэмдэглэв. Хүний наймаа эрхлэгчдийг шийтгэх үүднээс Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж хүн худалдаалах гэмт хэргийн тухай тусгасан. Тийм боловч, хүн худалдаалахтай холбогдсон гэмт хэргийн талаар тоо, бүртгэл дутмаг гэхчлэн шийдвэрлэх шаардлагатай асуудлууд байсаар байна. Хүн худалдаалагчдыг шийтгэж, хохирогчдын эрхийг хамгаалах зорилгоор Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн төслийг боловсруулж байна. Олон улсын хамтын нийгэмлэг болон дотоодын төрийн бус байгууллагуудын туслалцаатайгаар хүн худалдаалах асуудлыг үр дүнтэйгээр шийдвэрлэх зорилгоор олон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

50. Монгол Улсын Үндсэн хуулиар хүнийг хүйсээр болон бусад бүх үндсээр алагчлахыг хориглосон бөгөөд Үндсэн хуульд харшилсан аливаа хуулийг түүнд нийцүүлэн өөрчлөх ёстой. Тийнхүү аливаа алагчлах хэлбэр хууль бус болно. Гэсэн хэдий ч, уламжлалт хэв шинжүүд нийгэмд оршсоор буй тул нийгэм дэх тогтсон хандлагыг өөрчлөх үүднээс олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаа, сургалт явуулахад ихээхэн хүчин чармайлт гаргах хэрэгтэйг хүлээн зөвшөөрч байна.

51. Төлөөлөгчид ядуурлын асуудал нь хүн амын нийгэм-эдийн засгийн эрхээ эдэлж хэрэгжүүлэхэд саад учруулж буй ноцтой саад тотгорын нэг болохыг тэмдэглэв. Тиймээс Монгол Улсын Засгийн газар эдийн засгийн хурдацтай өсөлтийг дэмжихийн зэрэгцээгээр ядуурлыг бууруулах асуудалд тэргүүлэх ач холбогдол өгсөөр ирсэн болно. Эдийн засгийн хурдацтай өсөлт нь ядууралтай тэмцэх илүү сайн арга хэрэгслийг бүрдүүлж, шинээр ажлын байр бий болгоно.

52. Гэр бүлийн хүчирхийллийг арилгах, уг асуудлыг шийдвэрлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийг боловсруулан гаргасан хэдий ч практикт бэрхшээлтэй асуудлууд байсаар байна. Цагдаагийн ажилтнууд дээрх асуудлыг ихэнхдээ гэр бүлийн буюу хувийн шинжтэй хэмээн үзэж, төдийлөн тогтмол ач холбогдол өгдөггүй байна. Хохирогчид ихэнх тохиолдолд хүчирхийлэл үйлдэгчийн эсрэг гомдол гаргахгүй өнгөрдөг. МУ-ын Засгийн газар гэр бүлийн хүчирхийллийг үл тэвчих хандлагыг төлөвшүүлэх үүднээс олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх зэрэг замаар тэдгээр бэрхшээлийг шийдвэрлэхээр ажилласаар байна.

53. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээ, шаардлагыг шийдвэрлэх үүднээс холбогдох хууль тогтоомжийг сайжруулах чиглэлээр хүчин чармайлт гаргаж, олон тооны хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг төрийн байгууллагуудад авч ажиллуулах боломжийг цаашид судлах шаардлагатай. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаар олон нийтийн мэдлэг дутмаг байгаа тул МУ-

ын Засгийн газар дээрх бэрхшээлийг шийдвэрлэх арга хэмжээг бэхжүүлэх чиглэлээр үргэлжлүүлэн ажиллана.

54. Төрөл бүрийн хоол, хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх, чанарын тэжээллэг байдлын асуудлуудыг шийдвэрлэх үүднээс МУ-ын Засгийн газар тариалан эрхлэлтийг сэргээх хөтөлбөрийг эхлүүлсэн бөгөөд энэ нь сайн үр дүн өгч эхэлснийг Төлөөлөгчид тэмдэглэв.

55. **Турк Улс.** Хүний эрхийн олон улсын үндсэн баримт бичгүүдэд нэгдэн орсныг тэмдэглэн, Цагаач ажилчид болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенцод-д нэгдэн орох талаар Монгол Улс ямар байр суурьтай байгааг асууж тодруулав. Мөн бүх орон нутагт хууль зүйн туслалцаа үзүүлэх төвүүдийг байгуулсан, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дэмжих Үндэсний хөтөлбөр баталсныг сайшааж, энэ талаар нэмэлт мэдээлэл хүсэв. Түүнчлэн дунд сургууль болон их, дээд сургуулиудын элсэлтийн түвшин өндөр байгааг тэмдэглэж, төрөлтийн бүртгэлд анхаарал хандуулахыг санал болгов. Хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр олон улсын байгууллагуудын дэмжлэгийг авах шаардлагатайг тэмдэглэв. Турк Улс зөвлөмж гаргав.

56. **Итали Улс.** Монгол Улсын Ерөнхийлөгч 2010 оны 1 дүгээр сард мэдэгдэл гаргаж, цаазаар авах ялыг түдгэлзүүлсэн, мөн Монгол Улс Цаазаар авах ялын эсрэг олон улсын Комиссын бүрэлдэхүүнд орсныг сайшаав. Хүүхдэд бие махбодийн шийтгэл хэрэглэсээр буйг, мөн хүүхдийг аюултай хөдөлмөрт оролцуулах явдал нэмэгдсээр буйг онцоллоо. Итали Улс санал, зөвлөмжүүд гаргав.

57. **Бүгд Найрамдах Солонгос Улс.** Хүний эрхийг дэмжих, олон улсын конвенцуудыг соёрхон батлах, хүний эрхийн чиглэлээр дотоод институтуудыг сайжруулах талаар гаргасан ахиц дэвшлийг онцлов. Жендэрийн тэгш байдлын тухай хууль удахгүй батлагдана гэдэгт найдаж буйгаа илэрхийлж, хүчин төгөлдөр үйлчилж буй холбогдох хуулиудыг сайтар хэрэгжүүлэхийг уриалав. Монгол Улс иргэдийнхээ улс төрийн эрхийг дээшлүүлэх талаар авч хэрэгжүүлсэн алхмуудыг сайшааж, цаашид эмзэг бүлгүүдийн сонгох, сонгогдох эрхийг бэхжүүлэхэд анхаарал хандуулахыг хүсэв. БНСУ зөвлөмж гаргав.

58. **Бүгд Найрамдах Чех Улс.** Цаазаар авах ялыг түдгэлзүүлснийг сайшаав. БНЧУ санал, зөвлөмжүүд гаргав.

59. **Шинэ Зеланд Улс.** Бүртгэгдсэн эрүүдэн шүүсэн хэрэг, тохиолдлууд болон цагдаагийн байгууллагад хүч хэрэглэх явдал ихээхэн гарч буйг дурдав. 2010 онд цаазаар авах ялыг түдгэлзүүлснийг сайшаав. Эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг хууль тогтоомж дутмаг байгааг хөндөв. Шинэ Зеланд Улс санал, зөвлөмжүүд гаргав.

60. **Америкийн Нэгдсэн Улс.** Эмэгтэйчүүд болон насанд хүрээгүй охидыг алагчлах явдал, гэр бүлийн хүчирхийллийн түвшин өндөр байгааг тэмдэглэхийн зэрэгцээ хүүхэдтэй зүй бусаар харьцах, гэр бүлийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэрэгт зохих ял шийтгэл оногдуулж буйг сайшаав. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчлах, хүн худалдаалах гэмт хэрэг, мөн мөргөлийн газар барьж байгуулан, бүртгүүлэхэд шашны цөөнхөд тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэхэд анхаарахыг хүсэв. АНУ санал, зөвлөмжүүд гаргав.

61. **Пакистан Улс.** Хүний эрхийн олон улсын үндсэн 7 баримт бичгийг соёрхон баталж, хүний эрхийг хамгаалах, дэмжих чиглэлээр гаргасан хүчин чармайлтыг онцлов.



Хүний эрхийн талаарх албан бус сургалтыг хүн амд зориулан тогтмол зохион байгуулсныг сайшааж, энэ талаар нэмэлт мэдээлэл хүсэв. Түүнчлэн, “Найз 19–79” хэмээх хүүхэд хамгааллын тогтолцооны талаар асууж тодруулав. Монгол Улсад тулгарч буй байгаль орчны бэрхшээлтэй асуудлуудыг дурдав. Пакистан Улс санал, зөвлөмжүүд гаргав.

62. **Парагвай Улс.** Үндэсний цөөнхийн хүний эрхийг хамгаалах асуудал чухал бөгөөд энэ чиглэлээр төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд олон улсын хамтын нийгэмлэгээс ямар дэмжлэг, туслалцаа авч буйг асууж тодруулав. Далайд гарцгүй орон болох Парагвай Улс Монгол Улсын хөгжлийн асуудалд түүний газар зүйн байршил ихээхэн нөлөөлж буйг тэмдэглээд НҮБ-ын “Хөгжлийн туслалцаа” (Development Assistance Framework)-г авахыг санал болгов. Энэхүү асуудлыг Мянганы хөгжлийн 8 дугаар зорилтын хүрээнд өргөжин тэлж буй бүсийн хамтын ажиллагааны хүрээнд шийдвэрлэх боломжтойг дурдав.

63. **Аргентин Улс.** Цаазаар авах ялыг түдгэлзүүлснийг болоод Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийн төсөл боловсруулсныг сайшаав. Жендэрийн тэгш эрхийг хангах чиглэлээр гаргасан хүчин чармайлтыг онцолж, ижил хөлс, төлбөр олгох, мөн гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчингийн хэргийг шийтгэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар асууж тодруулав. Түүнчлэн хууль тогтоомжоор хүүхдийн хөдөлмөрийг устгах, ажил хийх насны доод хязгаарыг нэмэгдүүлэх боломжийг судлахыг уриалав. Аргентин Улс санал, зөвлөмжүүд гаргав.

64. **Испани Улс.** 1992 онд Үндсэн хуулиа баталснаас хойш хүний эрхийн салбарт гаргасан ахиц, дэвшил, хүний эрхийн олон улсын ихэнх баримт бичгийг соёрхон баталсныг онцлов. Цаазаар авах ял хуульд хүчин төгөлдөр хэвээр байгаад харамсаж буйгаа илэрхийллээ. Мөн Жендэрийн хүчирхийллийн эсрэг хуулийг баталсныг сайшаав. Хэдийгээр ЛГБТ-ийн асуудлыг гэмт хэрэгт хамруулаагүй ч Эрүүгийн хуулийн заалтууд ЛГБТ хүмүүсийн эсрэг ашиглагдаж болзошгүйг сануулав. 2008 оны 7 дугаар сард Сүхбаатарын талбайд болсон үйл явдлыг мөрдөн шалгах чиглэлээр ямар бодитой арга хэмжээ авсан талаар асууж тодруулав. Испани Улс санал, зөвлөмжүүд гаргав.

65. **Швейцарь Улс.** Хүний эрхийн салбарт гаргасан ахиц, дэвшил болон цаазаар авах ялыг түдгэлзүүлснийг сайшаав. Авлигатай тэмцэх асуудал хариуцсан байгууллагуудын бие даасан байдал, ажлын үр нөлөө нь дутагдалтай байгааг тэмдэглэв. Швейцарь Улс санал, зөвлөмжүүд гаргав.

66. **Португал Улс.** Цаазаар авах ялыг түдгэлзүүлснийг талархан сайшааж, уг ялыг улмаар хуулиар (de jure) халах, түүнийг улсын нууцын ангилалд үл хамруулах эсэх талаар асуув. Түүнчлэн тэнэмэл хүүхдүүдийн тоог багасгах, хүүхдийн хөдөлмөрийг хориглох чиглэлээрх төлөвлөгөөг сонирхов. Мөн Монгол Улс болон БНХАУ-ын Макаогийн ЗСОБ хооронд Хүн худалдаалахтай тэмцэх хоёр талт Хэлэлцээрийг талархан хүлээн авав. Португал Улс санал, зөвлөмжүүд гаргав.

67. **Словени Улс.** Тусгай илтгэгчидтэй байнга хамтран ажиллаж буйг болон цаазаар авах ялыг түдгэлзүүлснийг сайшаав. Эмэгтэйчүүдийг алагчилсан хуулийн заалтуудыг өөрчлөх, хөдөө орон нутгийн эмэгтэйчүүдийн төрөл бүрийн суурь үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэх, малчдын хүүхдүүд зэрэг янз бүрийн давхаргын хүүхдүүдийн боловсрох эрхийг хангах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар асууж

тодруулав. Словени Улс санал, зөвлөмжүүд гаргав.

68. **Гана Улс.** Цаазаар авах ялыг түдгэлзүүлснийг сайшаахын зэрэгцээ Эрүү шүүлтийн эсрэг хорооны мэдэгдсэнээр хуульд заасан эрүү шүүлт тулгах гэмт хэргийн тухай тодорхойлолт “Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц”–д нийцээгүй, мөн шүүн таслах ажиллагаанд эрүүдэн шүүх замаар олж цуглуулсан нотлох баримтыг ашиглаж буй талаар хөндөв. 2005 онд Жендэрийн тэгш байдлын Үндэсний хороог байгуулсныг тэмдэглэхийн зэрэгцээ Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах хорооны мэдэгдсэнээр тус хорооны эрх хэмжээ, хөрөнгө, нөөц дутмаг байдаг талаарх асуудлыг тэмдэглэв. Гана Улс санал, зөвлөмжүүд гаргав.

69. **Нидерланд Улс.** Цаазаар авах ялыг түдгэлзүүлснийг сайшааж, улмаар уг ялыг хална гэдэгт найдаж буйгаа илэрхийлэв. Эрүү шүүлтийн эсрэг хорооны мэдэгдсэнээр Монгол Улсад эрүүдэн шүүх явдал байсаар байгаа ба мөн хуульд заасан эрүү шүүлт тулгах гэмт хэргийн тухай тодорхойлолт “Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц”–д нийцээгүйг сануулав. ЛГБТ хүмүүст зориулсан төвийг байгуулсныг сайшаасан хэдий ч тэдгээр хүмүүсийн эсрэг хор хохирол учруулсан хэрэг тохиолдлууд бүртгэгдсэнийг тэмдэглэв. Нидерланд Улс санал, зөвлөмжүүд гаргав.

70. **Япон Улс.** 1992 оны Үндсэн хуулиар иргэдийн үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалан баталгаажуулсан явдлыг талархан сайшаав. Хүний эрхийн боловсролыг дэмжих Дэлхийн хөтөлбөрийн тухай НҮБ–ын Үйл ажиллагааны хөтөлбөр (2005–2009) хэрэгжилт, мөн эмэгтэйчүүдийн гэр бүлийн болон нийгмийн үүрэг, хариуцлагын талаарх уламжлалт алагчилсан шинжтэй дадлыг өөрчлөх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар асууж тодруулахын зэрэгцээ хүүхдийн бэлгийн мөлжлөгийн талаарх асуудлыг хөндөв. Япон Улс санал, зөвлөмжүүд гаргав.

71. **Казахстан Улс.** Хүний эрхийг хамгаалах, дэмжих чиглэлээрх хүчин чармайлт, ололт, түүнчлэн цаазаар авах ялыг түдгэлзүүлснийг сайшааж, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд жендэрийн асуудлыг харгалзах чиглэлээр хүчин зүтгэл гаргасныг онцлов. Түүнчлэн, хүний эрхийн олон улсын үндсэн баримт бичгүүдийг соёрхон баталсныг тэмдэглэлээ. Монгол Улс эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах талаар ямар бодит арга хэмжээ авч хэрэгжүүлснийг асууж тодруулав. Казахстан Улс санал, зөвлөмжүүд гаргав.

72. **Непал Улс.** Үндсэн хууль болон тусгай хууль, журмаар хүний эрхийг баталгаажуулсныг тэмдэглэн, Хүний эрхийн Үндэсний Комисс байгуулсныг талархан хүлээж авав. Далайд гарцгүй орон болох Непал Улс Монгол Улсад хөгжлийн томоохон сорилтууд тулгарч буйг хүлээн зөвшөөрч, байгаль орчныг хамгаалах, цаг уурын өөрчлөлтийн үр дагаврыг багасгах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг сайшаав. Түүнчлэн цаазаар авах ялыг түдгэлзүүлснийг сайшааж, цаашид уг ялыг халахыг уриалав.

73. **Бүгд Найрамдах Молдав Улс.** Хүний эрхийн Үндэсний Комиссын статус А үнэлгээгээр магадлан итгэмжлэгдсэн, Хүний эрхийн Үндэсний хөтөлбөрийг баталсан, мөн цаазаар авах ялыг түдгэлзүүлсэн явдалд баяр хүргэв. Сонгуулийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтүүдийг талархан хүлээн авахын зэрэгцээ Сонгуулийн ерөнхий хорооны талаар мэдээлэл хүсэв. 2008 онд үүссэн онц байдлын тухайд мөрдөн шалгалт явуулсныг сайшааж, хохирогчдод нөхөн төлбөр олгосон эсэх талаар асууж тодруулав. Жендэрийн

тэгш байдлын тухай хуулийн төслийг онцолж, үүнд тулгарч буй бэрхшээлтэй асуудлуудын талаар сонирхов. Асрамжийн төв байгуулах болон хүүхэд үрчлэлтийн асуудлыг хөндөж, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх замаар түүнтэй тэмцэхийг уриалав.

74. **Бангладеш Улс.** Монгол Улсын өмнө тулгарч буй шийдвэрлэх томоохон асуудлуудын нэг нь ядуурал хэмээн үзэв. Байгалийн гамшиг, цөлжилт, цаг уурын өөрчлөлт зэрэг нь хүн амын хүний эрхийг эдэлж хэрэгжүүлэхэд сөрөг нөлөө үзүүлж буйг тэмдэглэв. 1992 оны Үндсэн хуулиар хүний эрхийг баталгаажуулсан, Хүний эрхийн Үндэсний Комиссын статус А үнэлгээгээр магадлан итгэмжлэгдсэн, мөн бага, дунд сургууль болон дээд боловсролын элсэлтийн түвшин өндөр байгааг талархан тэмдэглэлээ. Бангладеш Улс санал, зөвлөмжүүд гаргав.

75. **Киргизстан Улс.** өнгөрсөн 18 жилийн хугацаанд иргэдийн эрх, эрх чөлөөг бэхжүүлэхэд ихээхэн ач холбогдол өгч, хүний эрх цэцэглэн хөгжих улс төр, эрх зүйн орчинг бүрдүүлснийг тэмдэглэв. Түүнчлэн бусад ардчилсан улс орнуудтай хамтран ажиллах замаар эрх, эрх чөлөөг дэмжин ажилласаар ирснийг онцлов. Үүнд Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа, МУ-ын Ерөнхий сайдаар ахлуулсан, төрийн байгууллагуудын хүний эрхтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулах үндсэн чиг үүрэг бүхий Хүний эрхийн Үндэсний Комисс зэрэг хүний эрхийг хамгаалах хүчирхэг механизмуудыг төлөвшүүлснийг дурдав. Хүн амынхаа нийгмийн болон соёлын эрхүүдийг баталгаажуулах үүднээс хүний эрхийн үндэсний чадавхыг бэхжүүлэх талаар цаашид илүү хүчин чармайлт гаргахыг уриалав.

76. **Украин Улс.** Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг баталсныг талархан хүлээн авав. Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах хорооны мэдэгдсэнээр эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, ажил эрхлэлт, тэдгээрийг улс төрийн болон олон нийтийн амьдралд оролцоход алагчилах явдлыг устгах арга хэмжээ дутагдалтай байгаа, мөн Хүүхдийн эрхийн хорооны мэдэгдсэнээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нийгмээс тусгаарлагдаж байгаа талаарх асуудлыг хөндөв. Украин Улс зөвлөмж гаргав.

77. **Исламын Бүгд Найрамдах Иран Улс.** Хүний эрхийг, тэр тусмаа эрүүл, аюулгүй орчинд амьдрах, өмчтэй байх, ажил эрхлэх, боловсрол олж авах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хамгаалах, дэмжих чиглэлээр гаргасан хүчин чармайлт, ололтыг сайшаав. ИБНИУ санал, зөвлөмжүүд гаргав.

78. Төлөөлөгчид хүний эрхийн тогтолцооны талаар ихээхэн чухал асуудлууд дэвшүүлснийг тэмдэглэв. Хүний эрхийн Үндэсний хөтөлбөрийн хорооны хуралдаанаар дунд сургуулиудад хүний эрхийн сургалт явуулах, ялангуяа боловсролын тогтолцоонд хүний эрхийн хичээлийг ямар байдлаар оруулах, хүний эрхийн хөтөлбөрүүдийг хэрхэн цогц байдлаар уялдуулах талаар хэлэлцсэн. Багш, сурагчдын харилцааг ойр болгох, хичээлийн материалуудыг харилцан уялдуулах нь дээрх хандлагын чухал бүрдэл хэсэг байв. Хүний эрхийн хичээлийг боловсролын тогтолцоонд багтаасан хэдий ч энэ талаар цогц, тогтмол арга барилыг нэвтрүүлэх шаардлага байгааг төлөөлөгчид онцлов.

79. Монгол Улс өнгөрсөн хугацаанд гадаадын хөрөнгө оруулагчдад ялгамжтай хандах зохицуулалт бүхий тогтолцоотой байсан ба саяхнаас дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдад тэгш байдлыг бий болгосноор энэхүү тогтолцоо өөрчлөгдсөн. Виз мэдүүлэх шаардлагууд ихээхэн хялбаршиж, онгоцны буудал дээр виз олгох боломжтой болсон.

80. Монгол Улс өөрийн тайван замаар ардчилалд шилжсэн түүхээр ямагт бахархдаг боловч 2008 оны 7 дугаар сард болсон сонгуулийн үр дүнг эсэргүүцсэн эсэргүүцэл нь энэ талаар цаашид илүү хүчин чармайлт гаргах шаардлагатайг сануулсан хэрэг болсон бөгөөд таван хүний амь үрэгдсэн нь хүлээн зөвшөөрч боломгүй явдал болохыг тэмдэглэв. Уг хэрэг явдлыг мөрдөн шалгах ажиллагааны хажуугаар УИХ-ын Хүний эрхийн дэд хороо 7 дугаар сарын 1-ний хэрэг явдлын талаар олон нийтийн хэлэлцүүлэг явуулж, цагдаагийн ажилтнууд болон эсэргүүцэгчидтэй олон нийтийн өмнө илээр ярилцлага хийсэн талаар төлөөлөгчид мэдэгдэв.

81. Тэнэмэл хүүхдүүдийн тоо ихэсч байгаа нь тулгамдаж буй асуудал бөгөөд Монгол Улсын Засгийн газар дээрх асуудлыг шийдвэрлэх үүднээс хүчин чармайлт гаргаж байна. Тэнэмэл хүүхдүүдийн тоо олширч буй нь ядуурлаас үүдэлтэйг төлөөлөгчид тэмдэглэж, тэдгээр хүүхдүүдийг асран хамгаалах халамжийн төвүүд байгуулах талаар хүчин чармайлт гаргаж буйг онцлов. Асрамжийн төвүүд байгуулахад олон улсын тусламж, дэмжлэг хэрэгтэйг төлөөлөгчид онцлон, холбогдох асуудлаар урт хугацааны шийдэл олох, мөн Засгийн газар уг бэрхшээлийг шийдвэрлэхэд илүү хөрөнгө зарцуулах шаардлагатайг тэмдэглэв.

82. Цаг уурын өөрчлөлтийн улмаас олон малчин мал сүргээ алдсанаас Улаанбаатар хотод нүүн суурьшихаас аргагүйд хүрч, улмаар хотын хүн ам нэмэгдсэний улмаас дэд бүтцийн хувьд Улаанбаатар хотын ачаалал улам ихэсч буйг төлөөлөгчид тэмдэглэв. Засгийн газар хүн амыг орон сууцжуулах чиглэлээр төрөл бүрийн хөтөлбөр боловсруулсан хэдий ч хүн амын 40 хувь буюу ойролцоогоор 1 сая хүн гэр хороололд амьдарч өвлийн улиралд нүүрс түлж байгаагаас өвлийн улиралд хотын хүрээлэн буй орчин ихээхэн бохирддог. Орчин үеийн, тохь тухтай, боломжийн үнэ өртөгтэй орон сууц барих нь асуудлыг шийдвэрлэх гарц мөн боловч энэ нь амаргүй юм. Шинээр үйлдвэрийн газрууд ихээр нэмэгдсэнээс шалтгаалан ус бохирдож, ноцтой асуудал үүсгээд байна. Засгийн газар байгаль орчны хяналтыг чангатгаж, бохирдуулагчдаас нөхөн төлбөр гаргуулах талаар хүчин чармайлт гаргасан бөгөөд агаарын бохирдлыг бууруулах, арилгах талаар үргэлжлүүлэн хүчин чармайлт гаргана.

83. УИХ-ын сонгуульд нэр дэвшигч эмэгтэйчүүдийн тоо өссөн боловч УИХ дахь эмэгтэй гишүүдийн тоо буурч байгаа нь улс төрийн намаас сонгуульд нэр дэвшигчдийн 30 хувь нь эмэгтэй байх тухай дотоод квотын бодлоготой холбоотойг төлөөлөгчид тэмдэглэв. УИХ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн төслийг хэлэлцэх зэрэг арга хэмжээг авч байна.

## **II. Дүгнэлт болон санал, зөвлөмжүүд**

84. Дор дурдсан, харилцан ярилцлагын явцад гарсан санал, зөвлөмжүүдийг Монгол Улс хянаж, дэмжив. Үүнд:

1. Хүмүүсийг хүчээр алга болгохоос хамгаалах олон улсын конвенцийг аль болох ойрын хугацаанд соёрхон батлах (Франц Улс);
2. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколыг соёрхон батлах боломжийг судлах (Мексик Улс);

3. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколыг соёрхон батлах, хууль хяналтын ажилтнуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх үр дүнтэй механизмыг нэвтрүүлэх (Шинэ Зеланд Улс);
4. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт Протокол, Хүмүүсийг хүчээр алга болгохоос хамгаалах олон улсын конвенцийг тус тус соёрхон батлах, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 22 дугаар зүйлийн дагуу мэдэгдэл гаргах (Испани Улс);
5. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактын нэмэлт Протоколыг соёрхон батлах (Аргентин Улс);
6. Хүмүүсийг хүчээр алга болгохоос хамгаалах олон улсын конвенцид нэгдэн орох (Аргентин Улс);
7. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын нэмэлт II Протоколыг соёрхон батлах (Бразил Улс, Испани Улс);
8. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг устгахад чиглэсэн нэмэлт II протоколд гарын үсэг зурж, түүнийг соёрхон батлах (Швед Улс, Португал Улс);
9. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын цаазаар авах ялыг устгахад чиглэсэн нэмэлт II протокол зэрэг холбогдох олон улсын баримт бичгүүдийг соёрхон батлах, Монгол Улсын эрх зүйн тогтолцооноос цаазаар авах ялыг халахад шаардлагатай алхмуудыг авч хэрэгжүүлэх (Австрали Улс);
10. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг устгахад чиглэсэн нэмэлт II протоколыг соёрхон батлах, хууль зүйн практикийг түүнтэй уялдуулах (Канад улс);
11. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколыг соёрхон батлах, цаазаар авах ялыг бүрмөсөн устгах үүднээс Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах (Словак Улс);
12. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколыг соёрхон батлах, улмаар үндэсний хууль тогтоомж, ялангуяа Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах (Итали Улс);
13. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколд даруй нэгдэн орох (Швейцар Улс);
14. Үндэсний хууль тогтоомжийг олон улсын стандартад уялдуулах, олон улсын стандартуудыг үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс шүүгчид болон хууль хяналтын ажилтнуудад сургалт түлхүү явуулах (Малайз Улс);
15. Хүүхдийн эрхийн конвенцид дотоодын хууль тогтоомжийг уялдуулах чиглэлээр үргэлжлүүлэн ажиллах, бие махбодийн шийтгэлийн бүх хэлбэрээс урьдчилан сэргийлэх, түүнийг устгах, 18 нас хүрээгүй хүүхдээр аюултай ажил хийлгэхээс сэргийлэх үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх (Итали Улс);
16. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад чухал ач холбогдол бүхий хууль, эрх зүйн акт, механизм, ялангуяа хохирогч болон гэрч, түүнчлэн хүний эрхийн өмгөөлөгчдийг хамгаалах, шийдвэр гаргах үйл явцад оролцох иргэний эрхийг баталгаажуулах, бэлгийн хүчирхийлэл, хэвлэн нийтлэгчдийн бие даасан байдал, УИХ-ын гишүүдийн

- хариуцлага, нийтийн ашиг сонирхол бүхий хэрэг, маргаанд оролцох иргэний нийгмийн эрхийн хангах зэрэг салбарт баталж нэвтрүүлэх (Унгар Улс);
17. Бэлгийн чиг хандлагаар алагчлахыг хатуу хориглосон, алагчлах явдлын эсрэг өргөн хүрээтэй хууль тогтоомж батлах (Канад Улс);
18. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн дагуу бие махбодийн шийтгэлийн бүх хэлбэрээс урьдчилан сэргийлэх, түүнийг устгах хууль тогтоомжийг батлах (Бразил Улс);
19. Хүний эрх зөрчих явдлыг хуулиас гадуур үлдээхгүйн үүднээс Эрүүгийн хуулийн 44.1 дэх хэсгийг хасах буюу өөрчлөх, мөн Эрүүгийн хуулийн эрүү шүүлт тулгах гэмт хэргийн тодорхойлолтыг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид нийцүүлэх чиглэлээр түүнд өөрчлөлт оруулах (Их Британи Улс);
20. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах явдлыг устгах зорилгоор хэрэгжүүлсэн санаачилгуудын хажуугаар үндэсний хууль тогтоомжийг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид, ялангуяа эрүү шүүлт тулгах гэмт хэргийн тодорхойлолтыг уялдуулан нийцүүлэх (Мексик Улс);
21. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн заалтуудтай уялдуулах зорилгоор эрүү шүүлт тулгах гэмт хэргийг зохих ёсоор тодорхойлох, мөн эрүү шүүлтийн дүнд олж цуглуулсан нотлох баримтыг аливаа шүүн таслах ажиллагаанд хэрэглэхгүй байх талаар Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах (Гана Улс);
22. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн тодорхойлолтыг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид нийцүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, мөн эрүү шүүлтийн дүнд олж цуглуулсан нотлох баримтыг аливаа шүүн таслах ажиллагаанд хэрэглэхгүй байхыг баталгаажуулах (Нидерланд Улс);
23. Хүн худалдаалах далд гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах, тэдэнд туслах зорилгоор хүний наймааны эсрэг хууль батлах (Индонез Улс);
24. Хүний наймааны эсрэг үндэсний хяналтын механизмыг бэхжүүлэхэд чиглэсэн хүн худалдаалахтай тэмцэх үндэсний тусгай, цогц хууль тогтоомж батлах (Польш Улс);
25. Хүний наймааны хохирогч болон гэрчүүдийг хамгаалах зорилгоор дотоодын хууль тогтоомжийг сайжруулах (Австрали Улс);
26. Хүүхдийн эрхийг дэмжих, хамгаалах үндэсний механизмыг бэхжүүлэх чиглэлээрх үүрэг амлалтаа үргэлжлүүлэн биелүүлэх (Исламын Бүгд Найрамдах Иран Улс);
27. Шинээр 10 жилийн хугацаатай Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах Үндэсний хөтөлбөрийг батлах талаар хүчин чармайлт гаргах (Алжир Улс);
28. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газраас батлан гаргасан 2008–2012 оны Үйл ажиллагааны төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэх (ОХУ);
29. Үндэсний Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хүний эрхийн санаачилгуудыг бүрэн хэрэгжүүлж, үр дүнтэйгээр хянах (Индонез Улс);
30. Ядуурлыг (ялангуяа хотын зах хэсгийн болон хөдөө, орон нутгийн) арилгах стратегийг хэрэгжүүлэхэд хүчин чармайлт гаргах (Индонез Улс);

31. Үндэсний нөхцөл байдал, ялангуяа эдийн засгийн хөгжил, ядуурлыг арилгах, нийгмийн эмзэг бүлгийн эрхийг хамгаалах зэргийг түлхүү харгалзан хүний эрхийн хүчин зүйлсэд түлхэц өгөх (БНХАУ);
32. Авлигын гэмт хэргийг Төрийн нууцын тухай хуулийн хүрээнд хамааруулах асуудлыг хязгаарлаж, үйл ажиллагаа, шийдвэрийг ил тод болгох, улмаар холбогдох шийтгэлийг бүрэн хэрэгжүүлэх үүднээс хяналтын байгууллагуудын бие даасан байдлыг хангах (Швейцари Улс);
33. Гадаадын иргэдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулахад түлхүү анхаарах (БНСУ);
34. УИХ болон Засгийн газрын шийдвэр гаргах үйл явцыг ил тод болгох, хууль тогтоомжийг олон нийтээр хэлэлцүүлэх явдлыг хангах бүтэц, зохион байгуулалтыг бий болгох (Их Британи Улс);
35. Үндэсний ээлжит хэлэлцүүлгээс гаргасан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн болон цөөнхийг төлөөлж буй байгууллагуудын оролцоог хангах (Норвеги Улс);
36. Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, мөн энэхүү хэлэлцүүлгийн мөрөөр хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дотоодын хүний эрхийн байгууллагуудыг хамруулах (Их Британи Улс);
37. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг дэмжих, сэтгэл зүйн болон дэд бүтцийн орчинг бүрдүүлж, тэдгээр хүмүүсийн эрхийг хамгаалахад холбогдох бүх байгууллагуудыг оролцуулах явдал нэн чухал (Казахстан Улс);
38. Нийгмийн эмзэг бүлгийн, ялангуяа эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, нийгмийн хамгаалал, ажил эрхлэлтийг дэмжих зорилгоор тусгай арга хэмжээ авч хэрэгжүүлэх (Исламын Бүгд Найрамдах Иран Улс);
39. Гэрээний байгууллагуудад тайлангаа тогтмол хүргүүлэх (ялангуяа 2003 оноос хойш хугацаа хоцорч буй Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын талаарх тайланг хүргүүлэхэд анхаарах) (Франц Улс);
40. Гэрээний байгууллагад үе шатны тайлангуудыг эцэслэж, хүргүүлэхэд онцгой анхаарах (Австрали Улс);
41. Хугацаа хоцорсон тайлангуудыг НҮБ-ын гэрээний байгууллагуудад даруй хүргүүлэхэд онцгой анхаарал хандуулах (Норвеги Улс);
42. Хүний эрхийн бүх гэрээний байгууллагуудад тайлангаа тогтмол хүргүүлэх (Словени Улс);
43. Хүмүүсийг, ялангуяа эмэгтэйчүүд болон хүүхдүүдийг худалдаалах асуудлаарх Тусгай илтгэгчтэй хамтран ажиллах (Шинэ Зеланд Улс);
44. Алагчлахын эсрэг хууль тогтоомжийг бэхжүүлж, түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэх замаар хүний эрхийг хангах (Норвеги Улс);
45. Шийдвэр гаргах дээд түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжиж, төрийн болон хувийн салбар дахь алагчлахтай тэмцэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх (АНУ);
46. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг баталж, тэгш байдлыг хангах механизмыг бий болгох (Гана Улс);

47. Эмэгтэйчүүд, охидтой зүй бусаар харьцах, тэднийг алагчлахтай тэмцэх талаар хүчин төгөлдөр үйлчилж буй хууль зүйн хамгаалалтыг бэхжүүлж, хэрэгжилтийг хангах (АНУ);
48. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг нэн даруй баталж, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах Үндэсний хороонд холбогдох эрх хэмжээг олгох, мөн эмэгтэйчүүдийг, ялангуяа орон нутаг дахь эмэгтэйчүүд зэрэг нийгмийн эмзэг бүлгийг алагчлах явдлыг арилгах талаар зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх (Словак Улс);
49. Ялангуяа хүйсээр алагчлахын бүхий л хэлбэрийг устгах цогц стратегийг боловсруулах замаар холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үндэсний хууль тогтоомжийг олон улсын баримт бичгүүдэд нийцүүлэх чиглэлээр хүчин чармайлт гаргах (Украин Улс);
50. Эмэгтэйчүүдэд адил тэгш боломж олгоход чиглэсэн бодлого боловсруулах (Нидерланд Улс);
51. Эмэгтэйчүүдийн ажил эрхлэх тэгш эрхийг баталгаажуулах (Норвеги Улс);
52. Ижил ажил гүйцэтгэсний төлөө тэнцүү хэмжээний хөлс олгох явдлыг баталгаажуулах (Норвеги Улс);
53. Эхчүүдийн хамгааллыг бэхжүүлэх (Норвеги Улс);
54. Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийг устгахад хүчин чармайлт гаргах (Норвеги Улс);
55. Тийм гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах, нийгэмшүүлэхэд анхаарч ажиллах (Норвеги Улс);
56. Бэлгийн чиг хандлагаар алагчлах, хүчирхийлэхийн бүх хэлбэрийг буруушааж, тийм халдлага, дайралтын хэргийг мөрдөн шалгаж, шийтгэх (Нидерланд Улс);
57. ЛГБТ хүмүүсийн эрхийг үр дүнтэй хамгаалахад чиглэсэн хууль тогтоомж боловсруулж, хүний эрхийн боловсрол, мэдээллийг олон нийтэд түгээх замаар ЛГБТ хүмүүсийг алагчлах үзлийг арилгах, (Швейцари Улс);
58. Бэлгийн чиг хандлагаар буюу хүйсээр алагчлах халдлагын хэргийг нягт мөрдөн шалгаж, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх (Канад Улс);
59. Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хүүхэд, эмэгтэйчүүд зэрэг эмзэг бүлгийн эрхийг хамгаалах, дэмжих чиглэлээр ажиллах (Куба Улс);
60. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлж, тэдгээрийн сонгох эрхийг хэрэгжүүлэх бүх нөхцлийг хангах (АНУ);
79. Хорих ял эдэлж байгаа болон цагдан хоригдож байгаа хүмүүсийг хамгаалах тухай НҮБ-ын Зарчим, Хоригдлуудтай харьцах наад захын жишгийн тухай НҮБ-ын стандартыг хэрэгжүүлэх замаар хорих байгууллагуудын нөхцлийг сайжруулах чиглэлээр ажиллах (Шинэ Зеланд Улс);
80. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд илүү хүчин чармайлт гаргах (Азербайджан Улс);
81. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон эмэгтэйчүүд, охидыг нөхөн сэргээх, нийгэмшүүлэх үр нөлөөтэй механизмыг бүрдүүлэх (Польш Улс);
82. Палермогийн протоколын хэрэгжилтийг хангах зорилгыг харгалзан, Хүүхдийн эрхийн хорооноос гаргасан зөвлөмжийн дагуу “Хүн худалдах ялангуяа хүүхэд,



- эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр” –ийг өргөн хүрээнд хэрэгжүүлэх (Мексик Улс);
83. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг гэмт хэрэгт татагдахаас сэргийлэх арга замыг эрэлхийлж, хүний наймааны хохирогчдод нөхөн төлбөр олгох, нийгэмшүүлэх асуудлыг анхаарах (Мексик Улс);
84. Бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгчдийг шийтгэх, хохирогчдыг хамгаалж дэмжлэг үзүүлэхэд хүчин чармайлт гаргах (АНУ);
85. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд олон нийтийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, хөгжүүлэх ажил өрнүүлэх (Канад Улс);
86. Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг бодлого хэрэгжүүлэх (Герман Улс);
87. Хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах, гэмт хэрэгтнийг шийтгэхэд институтын чадавхыг бэхжүүлэх (Канад Улс);
88. Бага насны хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгөөс үр дүнтэй хамгаалалахад анхаарч ажиллах (БНЧУ);
89. Бэлгийн мөлжлөгийн хохирогч болсон бага насны хүүхэд, эмэгтэйчүүдийг хамгаалах тусгай арга хэмжээг хэрэгжүүлж, тэдний нэр хүндийг болон тэднийг нөхөн сэргээхэд дэмжлэг үзүүлж ажиллах (БНЧУ);
90. Хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөгөөс сэргийлэх арга хэрэгслийг бэхжүүлж, тийм гэмт хэргийг шуурхай мөрдөн шалгаж, хэрэгтнийг шийтгэх (Аргентин Улс);
91. Хүүхдийг бэлгийн мөлжлөгөөс зохих ёсоор хамгаалах, тийм гэмт хэргийг сайтар мөрдөн шалгах, хэрэгтнүүдэд зүй ёсоор шийтгэл хүлээлгэхэд тулгарч буй саад тотгорыг арилгах арга хэмжээг шуурхай авах (Япон Улс);
92. Хүүхдийн хөдөлмөрийг зогсоох талаар үр дүнтэй арга хэмжээ авах (Азербайджан Улс);
93. Хүүхдүүдийн нөхцөл байдлыг сайжруулах, үүний хүрээнд хүүхдийн хөдөлмөрөөс үр дүнтэй сэргийлэхэд хүчин чармайлт гаргах (Герман Улс);
94. Хүн худалдаалах гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл, эмэгтэйчүүд, охидын эсрэг бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, ял завших явдлаас сэргийлэхийн тулд хууль хэрэгжүүлэх болон шүүх тогтолцоог бэхжүүлж сайжруулах (Малайз Улс);
95. Цагдаагийн албан хаагчдын үйлдсэн хүчирхийллийн гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах ажиллагааны зорилгоор Улсын ерөнхий прокурорын газрын Мөрдөн байцаах хэлтсийг бэхжүүлэх (Канад Улс);
96. ЛГБТ хүмүүсийг бэлгийн чиг хандлагын үүднээс заналхийлсэн, халдсан гэмт хэргийг нягт мөрдөн шалгаж, олон улсын шударга шүүхийн зарчмын дагуу буруутай этгээдийг шийтгэх (Швед Улс);
97. Эрүүдэн шүүсэн хэрэгт ял завшихтай тэмцэх (Герман Улс);
98. Зохих бүртгэлд хамрагдахад хүнийг итгэл үнэмшлээр үл алагчилах тухай дотоодын журам бий болгох (АНУ);
99. ЛГБТ хүмүүсийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхийг аливаа алагчлалгүйгээр хангах (Швед Улс);
100. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгох эрхийг бодитой хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авах (Словак Улс);

101. Хөгжлийн бэрхшээлтэй болон цагдан хоригдсон хүмүүсийн сонгох эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авах (Иран Улс);
102. Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх (Алжир Улс);
103. Ажилгүйдлийг бууруулах, хүнсний аюулгүй байдлыг дээшлүүлэхэд хүчин чармайлт гаргах (Азербайжан Улс);
104. Хоол тэжээлийн хомсдол, сүрьеэ өвчний эсрэг авах арга хэмжээний нөлөөг сайжруулах (Бангладеш Улс);
105. Нийт хүн ам, ялангуяа гэр хороололд оршин сууж буй хүмүүст эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүргэх, боловсрол эзэмших нөхцлийг бүрдүүлэх, ундны усны аюулгүй байдлыг хангах, эрүүл ахуйг бүрдүүлэх, мөн орон сууцжуулах чиглэлээр хүчин чармайлт гаргах (Словени Улс);
106. Иргэддээ эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авах (Пакистан Улс);
107. Үндэсний боловсролын болон эрүүл мэндийн тогтолцоог хөгжүүлэхэд хувийн хэвшлийн оролцоог түлхүү нэмэгдүүлэх (Иран Улс);
108. Хүрээлэн буй орчныг хамгаалах, нөхөн сэргээх үр нөлөөг сайжруулах, үүний хүрээнд холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох, байгаль орчны бохирдол, муудалтын үр дагаварын талаар нийтэд мэдээлэл, боловсрол олгох (Малайз Улс);
109. Дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлтөөс болон хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй, ялангуяа эрүүл ахуйн тогтолцооны талаарх тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулж, зохих арга хэмжээ авах (Иран Улс);
110. Иргэдийн сурч боловсрох эрх, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хангах хөтөлбөр, арга хэрэгслүүдийг хэрэгжүүлэх (Куба Улс);
111. Сургуулиас завсардах (ялангуяа хөвгүүд) явдлын эсрэг шаардлагатай арга хэмжээ авах (Алжир Улс);
112. Ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрт хүний эрхийн сэдвийг тусгах талаар идэвхтэй ажиллах (Турк Улс);
113. Уугуул иргэд болон омог, отгоор амьдардаг хүмүүст зохих хамгаалалт үзүүлэх (Словени Улс);
114. Улс орны нийгмийн болон эдийн засгийн хөгжлийн стратеги, төлөвлөгөөг сайтар хэрэгжүүлэх (Куба Улс);
115. Олон улсын хамтын нийгэмлэгийн дэмжлэгтэйгээр бэрхшээлтэй асуудлуудыг даван туулах (Бангладеш Улс);
116. Ард түмний хүний эрхийн төлөв байдлыг бүрэн хамгаалах, дэмжих зорилгоор НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагууд, олон улсын нийгэмлэгээс зохих хамтын ажиллагаа, техникийн туслалцаа үзүүлэхийг хүсэх (Малайз Улс);
117. Хүүхдийн хөдөлмөртэй тэмцэхэд Олон улсын Хөдөлмөрийн байгууллага зэргээр дамжуулан олон улсын туслалцаа эрэлхийлэх, хүсэх (Бразил Улс);
118. Иргэдийнхээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг шуурхай хангах үүднээс олон улсын түвшний техникийн хамтын ажиллагааг эрэлхийлэх (Пакистан Улс).

85. Дээр 5, 19, 20, 21, 22, 52–т дурдсан зөвлөмжүүд аль хэдийн хэрэгжсэн буюу хэрэгжих шатанд байгаа талаар Монгол Улс тэмдэглэв.

86. Дор дурдсан зөвлөмжүүдийг Монгол Улс судлан үзэж, 2011 оны 3 дугаар сард болох Хүний эрхийн Зөвлөлийн 16 дахь хуралдаанаас өмнө хариу өгөхөөр болов.

1. Бүх цагаач ажилчид, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай конвенцид нэгдэн орох (Аргентин Улс);
  2. Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай 1951 оны конвенц, түүний 1967 оны нэмэлт протоколд нэгдэн орох (Норвеги Улс);
  3. Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөөний зөрчлийн эсрэг арга хэмжээ авах эрх мэдлийг Үндсэн хуулийн цэцэд олгох. Энэ нь улмаар уугуул иргэд болон малчдын хүрээлэн буй орчин, газар ашиглахтай холбоотой эрхүүд болон ундны цэвэр ус хэрэглэх эрхийн зөрчлийг шийдвэрлэхэд тус дөхөм болох учиртай (Унгар Улс);
  4. Арьс өнгөөр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эмэгтэйчүүдийн алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц зэрэгт тусгагдсан гомдол хянан шийдвэрлэх механизмуудыг нэвтрүүлэх боломжийг судлах (Бразил Улс);
  5. ХДХВ/ДОХ болон аливаа бусад байдлаар алагчлах явдлыг хориглох, устгах, түүнээс урьдчилан сэргийлэх, ийм хэрэг үйлдэгчийг шийтгэхэд чиглэсэн шаардлагатай хууль тогтоомжийг батлан гаргах, шуурхай, үр нөлөө бүхий арга хэмжээг авч хэрэгжүүлэх (Мексик Улс);
  6. А үнэлгээтэйгээр магадлан итгэмжлэгдсэн ХЭҮК нь Жендэрийн тэгш байдлын тухай хууль боловсруулах, цаашлаад түүнийг хэрэгжүүлэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэвэл зохино (Унгар Улс);
  7. Шийдвэр гаргах дээд түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хангах (Норвеги Улс);
  8. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, бэлгийн чиг баримжаагаар болон хүйсээр алагчлахад хүргэж буй цагдаагийн албадын хүч хэрэглэх, хэрцгийгээр хандах зэрэг төрийн байгууллагын зүй бус үйл ажиллагаа болоод холбогдох хуулийн заалтуудыг халах, устгах (Испани Улс);
  9. Эрүүгийн хууль тогтоомжид өс хонзонгийн гэмт хэргийг тодорхойлон оруулах замаар тийм гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах (Канад Улс);
  10. Цаазаар авах ялаар шийтгэгдсэн хүмүүсийн талаарх мэдээллийг ар гэрийнхэнд нь өгөх зорилгоор өнгөрсөн хугацаанд оногдуулсан цаазаар авах ялуудыг төрийн нууцад хамааруулсныг цуцлах (БНЧУ);
  11. Цаазаар авах ял оногдуулсантай холбоотой мэдээллийг төрийн нууцын зэрэглэлд хамааруулах явдлыг арилгаж, цаазаар авах ял, түүний шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой мэдээлэл, статистик тоо баримтыг гаргах (Нидерланд Улс);
87. Энэхүү тайланд тусгагдсан бүхий л зөвлөмж, дүгнэлтүүд нь хэлэлцэж буй болон дүгнэлт гаргасан улс(ууд)–ын байр суурийг илэрхийлж буй бөгөөд Ажлын хэсэг тэдгээр дүгнэлт, зөвлөмжийг бүхэлд нь баталсан хэмээн үзэж үл болно.

### 9.3 МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТАЛААРХ ҮНДЭСНИЙ ИЛТГЭЛИЙГ НҮБ–ЫН ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨВЛӨЛ ХЭЛЭЛЦСЭН ТУХАЙ ТАЙЛАН МЭДЭЭ

2010 оны 11 дүгээр сарын 1–12–ны өдөр

Монгол Улс

Энэхүү илтгэл нь НҮБ–ын хүний эрхийн байгууллагуудын тусгай журмын дагуу Орлоцогч холбогдох улсуудаас хийсэн тайлбар, санал болон НҮБ–ын холбогдох байгууллагуудын албан ёсны баримт бичигт тусгасан тайлан мэдээг агуулсан болно. Хүний эрхийн дээд комиссарын газар (ХЭДКГ)–ын олон нийтэд нээлттэй илтгэлд өгүүлсэн үзэл бодол, саналаас бусад аливаа үзэл бодол, саналыг тусгайлан энэхүү илтгэл агуулаагүй болно. Энэхүү илтгэлийг Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан үндсэн заавар зөвлөмжийн дагуу үйлдсэн. Илтгэлд орсон мэдээллийг ишлэл зүүлтээр сүүлд системчилэн үзүүлсэн болно. Энэхүү илтгэлийг бэлтгэхэд 4 жил тутам хэлэлцүүлэг хийх давтамжийн эхний удаагийнх нь болохыг харгалзан үзсэн. Сүүлийн үеийн мэдээ мэдээлэл байхгүй тохиолдолд хамгийн сүүлд гарсан илтгэл тайланд дурдсан мэдээ мэдээллийг хуучирсан эсэхийг үл харгалзан энэхүү тайланд ашиглав. Мэдээллийн дутуу дулимаг байдал эсвэл тодорхой асуудлыг хангалттай хөндөөгүй нь холбогдох гэрээ хэлэлцээрийг соёрхон батлаагүй буюу/эсвэл олон улсын хүний эрхийг хамгаалах механизмтай хамтын ажиллагаа буюу харилцаа доогуур түвшинд байгаатай холбоотой.

#### I. Ерөнхий мэдээлэл болон ерөнхий бүтэц

##### A. Олон улсын хүрээнд хүлээсэн үүрэг<sup>1</sup>

<i>Хүний эрхийн чиглэлээрх түгээмэл гэрээ хэлэлцээр</i>	<i>Соёрхон баталсан, нэгдэн орсон огноо</i>	<i>Мэдэгдэл/тайлбар</i>	<i>Гэрээнд суурилсан байгууллага хүлээн зөвшөөрсөн эсэх</i>
Арьс үндсээр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц	1969 оны 8 дугаар сарын 6	тийм (17 зүйл)	хувь хүний гомдол (14 дүгээр зүйл): үгүй
Эдийн засаг нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт	1974 оны 11 дүгээр сарын 18	тийм (21 зүйл (1))	-
Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт	1974 оны 11 дүгээр сарын 18	тийм (48 зүйл (1))	улс хоорондын гомдол (41 дүгээр зүйл): үгүй
Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протокол-1	1991 оны 4 дүгээр сарын 16	-	-
Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц	1981 оны 7 дугаар сарын 20	-	-
Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн нэмэлт протокол	2002 оны 3 дугаар сарын 28	-	Хянан шалгах ажиллагаа (8,9 дүгээр зүйл): үгүй

## ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц	2002 оны 1 дүгээр сарын 24	-	улс хоорондын гомдол (21 дүгээр зүйл): үгүй  хувь хүний гомдол (22 дүгээр зүйл): үгүй  хувь хүний гомдол (20 дүгээр зүйл): үгүй
Хүүхдийн эрхийн тухай конвенц	1990 оны 7 дугаар сарын 5	-	-
Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцийн нэмэлт протокол	2004 оны 10 дугаар сарын 6	Конвенцийн 3:18 жил зүйлд тайлбар	-
Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн конвенцийн нэмэлт протокол	2003 оны 6 дугаар сарын 27	-	-
Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц	2009 оны 5 дугаар сарын 13	-	-
Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн нэмэлт протокол	2009 оны 5 дугаар сарын 13	-Хянан шалгах ажиллагаа (6,7 дугаар зүйл): тийм	-

*Монгол Улсын оролцогч бус олон улсын гэрээ:* Эдийн засаг нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протокол (зөвхөн гарын үсэг зурсан, 2009 он), Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар нэмэлт протокол, Эрүүдэн шүүх болон бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн 2 дугаар нэмэлт протокол, Бүх цагаач ажилчид тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн хүний эрхийг хамгаалах тухай конвенц болон Хүчээр сураггүй алга болохоос бүх хүнийг хамгаалах тухай конвенц (зөвхөн гарын үсэг зурсан, 2007 он)

### Тусгай үйл ажиллагаан дахь хамтын ажиллагаа

Байнгын урилга байгаа эсэх	Байгаа
Хамгийн сүүлийн албан айлчлал эсвэл илтгэл зөвлөмжүүд	Сурч боловсрох эрх хариуцсан тусгай илтгэгч 10 дугаар сарын 1–8 2009 он; Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс хүний эрхийн төлөв байдлын асуудал хариуцсан тусгай илтгэгч (9 дүгээр сарын 24–өөс 10 дугаар сарын 1–ний өдөр хүртэл 2009 онд; 12 дугаар сарын 15–21 хооронд 2007 онд, 12 дугаар сарын 18–23 хооронд 2006 онд).
Гэрээ хэлэлцээрт хүрсэн албан айлчлал	-
Захиалгатай боловч зөвшилцөөгүй айлчлалууд	-
Айлчлалын үе дахь хамтын ажиллагаа	Сурч боловсрох эрх хариуцсан тусгай илтгэгчийн айлчлалыг амжилттай зохион байгуулахад Монгол Улс дэмжлэг үзүүлсэнд талархал илэрхийлсэн.
Айлчлалтай холбоотой арга хэмжээ	Эрүүдэн шүүхийн асуудал хариуцсан тусгай илтгэгч 2008 болон 2010 онд.

Хойшуулшгүй арга хэмжээ авах тухай захианы	Тайлангийн хугацаанд нийт 7 захидал илгээсэн бөгөөд Засгийн Газар 5 захидалд хариу өгсөн
Тодорхой сэдвийн хүрээнд өгсөн хариу	Тусгай эрх мэдэл бүхий этгээдээс явуулсан 23 асуултын 2 асуултад Монгол Улс хариу өгсөн

---

1. НҮБ-ын зарим гэрээнд суурилсан болон/эсвэл тусгай процедурт суурилсан байгууллагууд Монгол Улсыг Бүх цагаач ажилчин тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай конвенц, Хүчээр алга болохоос бүх хүнийг хамгаалах тухай конвенц, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протокол, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар нэмэлт протокол, Эдийн засаг нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протокол, Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай 1951 оны олон улсын конвенц болон 1967 оны нэмэлт протокол, Харьяалалгүй хүмүүсийн эрх зүйн байдлын тухай 1954 оны конвенц, Харьяалалгүй хүмүүсийн цөөрүүлэх тухай конвенц болон Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Эхчүүдийг хамгаалах тухай №183 дугаар конвенцуудыг соёрхон батлахыг зөвлөж байна.

2. НҮБ-ын Арьс үндсээр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах хороо нь Монгол Улсыг Арьс үндсээр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх конвенцийн 8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн нэмэлт өөрчлөлтийг соёрхон баталж, тус конвенцийн 14 дүгээр зүйлд заасны дагуу мэдэгдэл хийхийг зөвлөж байна.

3. Хороо нь хувь хүний гомдол хүлээн авах эрх мэдлийг Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн 22 дугаар зүйлийн дагуу хүлээн зөвшөөрөх талаар мэдэгдэл хийхийг Эрүүдэн шүүхийн асуудал хариуцсан тусгай илтгэгч Монгол Улсад хандан зөвлөмж болгосон.

#### **В. Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд**

4. Монгол Улсын хууль тогтоомж Хүүхдийн эрхийн тухай конвенцид нийцэхгүй байгаад санаа зовниж буйгаа Хүүхдийн эрхийн хороо 2010 онд мэдэгдсэн бөгөөд тус конвенцид нийцүүлэн үндэсний хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулахаа үргэлжлүүлэх талаар зөвлөмж болгосон. Түүнчлэн хүүхдийн эрхийг хамгаалсан цогц хууль тогтоомж батлахыг Хорооноос мөн зөвлөсөн.

5. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг устгах хороо Монгол Улсыг үндэсний хууль тогтоомжид одоо хүртэл эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах зүйл, заалт байж болох, мөн үндэсний хууль тогтоомжоо конвенцид нийцэж байгаа эсэхэд дүгнэлт хийгээгүйд санаа зовж байгаагаа 2008 онд илэрхийлсэн. Хороо нь бүх хүчин төгөлдөр үйлчилж буй үндэсний хууль тогтоомжид дүгнэлт хийж, эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалт агуулж буй бүх зүйл, заалтад нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгтэй талаар мэдэгдсэн. Хороо нь шууд болон шууд бус ялгаварлан гадуурхалтын тодорхойлолтыг агуулсан Жендэрийн тэгш байдлын тухай хууль батлах хэрэгтэй байгааг бас мэдэгдсэн. Түүнчлэн хороо Монгол Улсыг бэлгийн хүчирхийллийн эсрэг хууль

тогтоомж батлахыг уриалсан.

6. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Конвенцийн хэрэгжилт, зөвлөмжийн хороо (Олон улсын хөдөлмөрийн байгууллагын шинжээчдийн хороо) Хөдөлмөрийн тухай хуульд ижил хөдөлмөр эрхэлдэг эрэгтэй, эмэгтэй хүмүүс ижил хөлс олгохоор 2008 болон 2009 онд заасан байдаг. Энэ нь ОУХБ-ын №100 дугаар конвенцтой харьцуулбал илүү нарийн хүрээнд авч үзэж байгаа бөгөөд үүнд зөвхөн ижил ажил гэхгүйгээр ижил гэж үнэлэгдэх бүх төрлийн ажил орж байгаа юм. Иймд хороо эрэгтэй эмэгтэй хүмүүсийн ижил үнэлэмжтэй хөдөлмөрийн цалин хөлсийг ижил хэмжээнд олгох тухай хууль тогтоомж батлахыг зөвлөж байна.

7. Одоогийн хүчин төгөлдөр байгаа хууль тогтоомжид арьс үндсээр ялгаварлан гадуурхалтын тодорхойлолт байхгүй байгаад санаа зовж байгаагаа Арьс үндсээр ялгаварлан гадуурхах явдлыг устгах хороо 2006 онд илэрхийлсэн. Мөн иргэний болон захиргааны хүрээнд арьс үндсээр ялгаварлан гадуурхалтын асуудлаар хууль тогтоомж байхгүй байгаад сэтгэл зовниж буйгаа илэрхийлж, арьс үндсээр ялгаварлан гадуурхах үзэл бодлыг баримталж дэмждэг байгууллагын үйл ажиллагааг хууль бус гэж үзэн хориглох талаар ямар ч хууль тогтоомж байхгүй байгааг мэдэгдсэн. Иймд арьс үндсээр ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх, түүний хориглох талаар хууль батлахыг зөвлөмж болгосон.

### **С. Зохион байгуулалт болон хүний эрхийг хамгаалах дэд бүтэц**

8. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс Хүний эрхийн үндэсний байгууллагуудын олон улсын зохицуулах хороонд “А” статусаар 2008 онд магадлан итгэмжлэгдсэн.

9. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг устгах хорооноос Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс байгуулагдсаныг 2000 онд сайшаасан. Гэхдээ Комисст ирж байгаа ихэнх өргөдөл, гомдол Улаанбаатар хотын иргэдээс ирж байгаад санаа зовж байгаагаа мэдэгдсэн. Мөн түгээмэл тархалттай эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс өөр хүйсээр ялгаварлан гадуурхсан талаарх гомдол ирээгүйд Хороо санаа зовж байгаагаа мэдэгдсэн. Эмэгтэйчүүдээс хүлээн авсан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх Хүний эрхийн Үндэсний Комиссын эрх мэдлийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаагаа идэвхжүүлэхийг Хорооноос Монгол Улсад хандан зөвлөмж болгосон. Хүний эрхийн Үндэсний Комисс нь хүүхдүүдээс ирүүлэх өргөдөл гомдлыг тэдэнд ойлгомжтой хялбар аргаар хүлээн авахуйц чиг үүрэг буюу чадавхтай байх боломжийг хангах талаар арга хэмжээ авахыг Монгол Улсад хандан Хүүхдийн эрхийн хорооноос мөн зөвлөмж болгосон.

10. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг устгах хорооноос 2005 онд Жендэрийн тэгш байдлын хороо байгуулсныг сайшааж байна. Гэвч энэхүү байгууллагын талаарх мэдээлэл хомс, эмэгтэйчүүдийн жендэрийн тэгш байдлыг хангах талаар хангалттай мэдээ мэдээлэл, эх сурвалжаар хангаж чадахгүй байгаад харамсаж байна.

**D. Бодлогын хүрээнд**

11. Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр (2002–2010 оны) баталсныг Хүүхдийн эрхийн хорооноос тэмдэглэхийн хамт түүнийг хэрэгжүүлэх зохих эх үүсвэр, үйл ажиллагаанд нь үнэлэлт дүгнэлт өгөх механизм бүхий шинэ төлөвлөгөө боловсруулахыг зөвлөмж болгосон.

12. Хүүхдийн эрхийн хороо нь “Хүн худалдах, ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах” үндэсний хөтөлбөрт Палермогийн протоколд орсон бүх зөрчлүүдийг тусгаж чадаагүйд сэтгэл зовниж байна.

13. Монгол Улс үндэсний боловсролын байгууллагуудын хичээлийн хөтөлбөрт хүний эрхийн чиглэлээр боловсрол олгох НҮБ–ын үйл ажиллагааны төлөвлөгөөг (2005–2009) 2005 онд баталсан.

**II. Хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих**

**A. Хүний эрхийг хамгаалах механизмын хамтын ажиллагаа**

**1. Гэрээний байгууллагуудын хамтын ажиллагаа**

Гэрээний байгууллага	Хамгийн сүүлд хэлэлцсэн илтгэл	Хамгийн сүүлд өгсөн зөвлөмж	Авсан арга хэмжээний талаарх мэдээлэл	Өргөн барьсан илтгэлийн тайлбар
Арьс үндсээр ялгаварлан гадуурхах явдлыг устгах хороо	2005 он	8 дугаар сард	–	2010 онд өргөн барих байсан 19, 20, 21 дүгээр илтгэлүүд
Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн хороо	1998 он	2000 оны 8 дугаар сард	–	2003 онд өргөн барих байсан 4 дүгээр илтгэл
Хүний эрхийн хороо	1998 он	2000 оны 3 дугаар сард	–	2003 онд өргөн барих байсан боловч 2009 онд өргөн барьсан 5 дугаар илтгэл
Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг устгах хороо	2007 онд	2008 оны 10 дугаар сард	2010 оны 10 дугаар сард өргөн барьсан байх	2014 онд өргөн барих 8, 9 дүгээр илтгэл
Эрүүдэн шүүхийн эсрэг хороо	–	–	–	2003 онд анхдугаар илтгэлийг өргөн барих байсан
Хүүхдийн эрхийн хороо	2008 онд	2010 оны 1 дүгээр сард	–	2014 онд өргөн барих 5 дугаар илтгэл



## ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцийн нэмэлт протокол	2008 онд	2010 оны 1 дүгээр сард	–	–
Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн конвенцийн нэмэлт протокол	2008 онд	2010 оны 1 дүгээр сард	–	–
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай конвенцийн нэмэлт протокол	–	–	–	2011 онд өргөн барих 11 дүгээр илтгэл

## 2. Тусгай үйл ажиллагаан дахь хамтын ажиллагаа

Байнгын урилга байгаа эсэх	Байгаа
Хамгийн сүүлийн албан айлчлал эсвэл илтгэл зөвлөмжүүд	Сурч боловсрох эрх хариуцсан тусгай илтгэгч 10 дугаар сарын 1–8 2009 он;  Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын хүний эрхийн асуудал хариуцсан тусгай илтгэгч (9 дүгээр сарын 24–өөс 10 дугаар сарын 1–ны өдөр хүртэл 2009 онд; 12 дугаар сарын 15–21 хооронд 2007 онд, 12 дугаар сарын 18–23 хооронд 2006 онд).
Гэрээ хэлэлцээрт хүрсэн албан айлчлал	–
Захиалгатай боловч зөвшилцөөгүй айлчлалууд	–
Айлчлалын үе дахь хамтын ажиллагаа	Сурч боловсрох эрх хариуцсан тусгай илтгэгчийн айлчлалыг амжилттай зохион байгуулахад Монгол Улс дэмжлэг үзүүлсэнд талархал илэрхийлсэн.
Айлчлалтай холбоотой арга хэмжээ	Эрүүдэн шүүхийн асуудал хариуцсан тусгай илтгэгч 2008 болон 2010 онд.
Хойшлуулшгүй арга хэмжээ авах тухай захианы	Тайлангийн хугацаанд нийт 7 захидал илгээсэн бөгөөд Засгийн Газар 5 захидалд хариу өгсөн
Тодорхой сэдвийн хүрээнд өгсөн хариу	Тусгай эрх мэдэл бүхий этгээдээс явуулсан 23 асуултын 2 асуултад Монгол Улс хариу өгсөн

**В. Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн хүрээнд хүний эрхийн чиглэлээр хүлээсэн олон улсын үүргийн хэрэгжилт**

**1. Эрх тэгш байдал ба ялгаварлан гадуурхахгүй байх явдал**

14. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг устгах хороо нь ялгаварлан гадуурхалтыг суурь үндсээр нь арилгах чиглэлээр, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гэр бүл болон нийгэм дэх ялгаатай үүрэг нь хууль тогтоомж, улс төрд илэрдэг бөгөөд энэ талаар хангалттай арга хэмжээ аваагүйд санаа зовниж байгаагаа илэрхийлсэн. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо мөн адил асуудлаар санаа зовниж байгаагаа мэдэгдсэн.

15. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг устгах хороо эмэгтэйчүүдийн дунд ажилгүйдэл их байгаад санаа зовниж байгаагаа илэрхийлж Монгол Улс дахь эмэгтэйчүүдийг хөдөлмөрлөх эрхээр адил тэгш хангахыг уриалсан.

16. Төрийн болон хувийн байгууллагад эмэгтэйчүүдийг ажилд авахад ялгаварлан гадуурхах, ижил үнэлэмжтэй ажил хийсэн эрэгтэй, эмэгтэй хүнд адил тэнцүү цалин хөлс олгох, эх хүнийг хамгаалах болон Хөдөлмөрийн тухай хууль дахь ялгаварлан гадуурхалт бүхий агуулгатай заалт байгаад Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг устгах хороо санаа зовниж байна. Орчин үеийн амьдралын хэв маягаас үүдэн эмэгтэйчүүдийн чадавх, нийгэмд гүйцэтгэх үүрэг нь адил тэгш эрхтэй байх буюу боломжоор хангагдах эрхийг зөрчилд хүргэж буй тул тэднийг хамгаалах тусгай арга хэмжээ (хөдөлмөрийн тухай хууль дахь) авахыг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Шинжээчдийн хорооноос Монгол Улсад хандан зөвлөж байна.

17. Эмэгтэйчүүд боловсролын хүрээнд томоохон амжилтад хүрсэн хэдий ч тэд өндөр цалин хөлстэй ажил болон удирдах албан тушаалаар хангагдаж бараг чаддаггүй хэвээр байгаад Хөдөлмөрийн байгууллагын шинжээчдийн хороо 2010 онд тэмдэглэсэн. НҮБ-ын орон хариуцсан баг мөн адил зүйлийг ажиглаж, эмэгтэйчүүд ихэвчлэн бага цалинтай хөдөө аж ахуй, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, боловсролын болон эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж байгааг цохон тэмдэглэсэн.

18. НҮБ-ын орон хариуцсан баг мөн сонин хэвлэлд нийтлэгдсэн зарим өндөр албан тушаалуудад нас, хүйсийн шаардлага тавигддаг бөгөөд нас, хүйс болон нийгмийн гарлаар ялгаварлан гадуурхалт хэвээр байгааг тэмдэглэсэн.

19. Орон нутагт эрүүл мэндийн үйлчилгээ, цэвэр усаар хангагдах, ариун цэврийн үйлчилгээнд хамрагдах болон тухайн орон нутгийн хүрээнд ямар нэг шийдвэр гаргахад оролцох асуудлууд хөдөөгийн эмэгтэйчүүдийн хувьд хүндрэлтэй байгаад Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг устгах хороо санаа зовниж байна. Хороо нь Монгол Улсыг хөдөөгийн эмэгтэйчүүдийг ямар нэг ялгаварлан гадуурхалгүй шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох боломжоор хангах, эрүүл мэндийн үйлчилгээ, цэвэр усаар хангагдах болон ариун цэврийн үйлчилгээнд хамруулах үйл ажиллагаанд анхаарал хандуулахыг уриалсан байна.

20. Ялгаварлан гадуурхалтад өртөж болох эмзэг бүлгийн хүүхдүүдийг хамгаалах үйл ажиллагааг Хүүхдийн эрхийн хорооноос тэмдэглэхийн хамт эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийг хүйсээр нь, үндэс угсаагаар нь, хөгжлийн бэрхшээлтэй байдлаар нь, хүүхдийн амьжиргаа, гэр бүл болон амьдардаг газраар нь ялгаварлан гадуурхах явдал хэвээр байгаад санаа

зовнисон хэвээр байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд зохистой дэд бүтэц байхгүйн улмаас нийгмээс тусгаарлагдаж, боловсролоор хангагдах боломжгүй, нийгмийн хангамж болон эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаад Хороо санаа зовниж байна.

21. Боловсролын асуудал хариуцсан тусгай илтгэгч албан бус боловсрол олгодог төвүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тусгаарласан асуудлыг хөндөж, хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг аажим аажмаар ерөнхий боловсролын системд оруулах хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхийг зөвлөсөн.

## **2. Амьд явах, эрх чөлөөтэй байх, хувь хүний халдашгүй байх эрх**

22. Эрүүдэн шүүхийн асуудал хариуцсан тусгай илтгэгч цаазаар авах ялын нөхцөл байдал болон цаазаар авах ял нь төрийн нууцад хамаарч байгаад санаа зовниж буйгаа 2005 онд илэрхийлсэн. Түүнчлэн тэрээр цаазаар авахуулсан хүмүүсийн тоо, цаазаар авсан хугацаа, байршлын талаар албан ёсоор мэдээлэл ирүүлэхийг нэг бус удаа хүссэн боловч түүнд ямар ч мэдээлэл өгөөгүй, цаазаар авахуулсан хүмүүсийн гэр бүлд мөн адил энэ талаар ямар ч мэдээлэл өгдөггүй бөгөөд биеийг нь оршуулахаар гэр бүлд нь өгдөггүйг мэдэгдсэн байна. 2005 болон 2008 онд дараах зөвлөмжүүдийг өгсөн: а) цаазаар авах ялаар шийтгүүлсэн хүмүүсийг олон улсын жишигт нийцсэн камерт байрлуулах, гавлаж уяж хүлэхгүй байх б) цаазаар авах ялаар шийтгүүлэх тухай шийдвэрийг түдгэлзүүлэх.

23. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 1 дүгээр сард гаргасан албан ёсны шийдвэрээр Монгол Улс цаазаар авах ялыг түдгэлзүүлж, цаазаар авах ял эдлэхээр камерт хоригдож байгаа хүмүүсийн ялыг хорих ялаар сольсон тухай мэдэгдлийг Хүний эрхийн дээд комиссар талархан хүлээн авсан. Мөн цаазаар авах ялыг цаашид бүр мөсөн халахын тулд Монгол Улсыг Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт 2 дугаар протоколыг соёрхон батлахыг тэрбээр мөн зөвлөжээ. Эрүүдэн шүүхийн асуудал хариуцсан тусгай илтгэгч мөн адил цаазаар авах ялыг түдгэлзүүлснийг сайшаан, уг ялыг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хална гэдэгт найдаж байгаагаа мэдэгдсэн.

24. Эрүүдэн шүүхийн асуудал хариуцсан тусгай илтгэгч Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн дагуу эрүү шүүлтийн тодорхойлолт хууль тогтоомжид байхгүй бөгөөд хууль хамгаалах байгууллагын ажилтнууд одоо хүртэл эрүүдэн шүүсээр байгааг 2005 онд тэмдэглэсэн байдаг. Монгол Улс холбогдох хууль тогтоомждоо 2010 онд санаачлагаараа нэмэлт оруулж, эрүү шүүлтийг эрүүгийн гэмт хэрэг болгон өөрчилснийг тэрбээр сайшааж байгаа хэдий ч эрүү шүүлтийн тодорхойлолт нь конвенцийн шаардлагад нийцэхгүй байгаад харамсал илэрхийлж байна. Мөн шүүх хуралд эрүү шүүлтээр олж мэдээ мэдээллийг ашиглахгүй байх заалт Эрүүгийн байцаан шийтгэх хуульд байхгүй байгаад санаа зовниж байна.

25. Эрүүдэн шүүхийн асуудал хариуцсан тусгай илтгэгч Хүний эрхийн Үндэсний Комисс болон прокурорын байгууллагын өргөдөл гомдол хүлээж авах, мөн хянаж шалгах ажиллагааг өндрөөр үнэлж энэхүү механизмуудын хараат бус байлгах, үйл ажиллагааг үргэлжлүүлэх зорилгоор зохих хэмжээний санхүүгийн дэмжлэг үзүүлэх шаардлагатай

байгааг 2010 онд тэмдэглэсэн. Мөн тэрбээр Үндэсний хамгаалах механизм байгуулахыг Монгол Улсад зөвлөсөн.

26. Монгол Улсад олон нийтийн үймээн самууныг тараахад хүч хэрэглээнд санаа зовниж байгаагаа НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга 2008 оны 7 дугаар сарын 2-ны өдөр илэрхийлж энэхүү явдлаас болж амь үрэгдсэн хүмүүст эмгэнэл илэрхийлсэн. 2008 онд зарласан онц байдлын үед жагсаалд оролцогчдоос 4 хүн амь үрэгдсэн тухай Тусгай эрх бүхий этгээдээс хамтарсан мэдээлэл хүргүүлсэн. Улаанбаатар хотод болж өнгөрсөн сонгуулийг эсэргүүцсэний улмаас 7 дугаар сарын 1-ны өдөр 700 хүн саатуулагдсан. Үүний дараа Засгийн газар 4 хоногийн онц байдал зарлах тухай шийдвэр гаргасан. Саатуулагдсан хүмүүсийн ихэнхийн эрх чөлөөнд халдаж, хоол хүнс, ус өгөхгүй хорьж байсан бөгөөд тэдэнд хүчээр хэрэг тулгаж байсан гэж мэдээлэлд тусгасан байсан. Улаанбаатар хотын төв гудамжинд 4 хүн буудуулж амь насаа алдсан бөгөөд буудуулахаасаа өмнө тэд зодуулсан гэсэн мэдээлэл ирсэн. Хууль зүйн шаардлагыг хангах үүднээс олон нийтийн үймээн самууныг хүчээр тараах эрхийг цагдаагийн байгууллагад олгохын тулд Ерөнхийлөгч онц байдал зарлаж, цагдаагийн байгууллага үүнийг удирдлага болгон нийгмийн хэв журмыг сахиулах арга хэмжээ авсан гэж Засгийн газар хариу өгсөн. Мөн 4 хүний амь насыг хөнөөсөнтэй холбогдуулан цагдаагийн байгууллагын 106 албан хаагчаас байцаалт авч, 10 албан хаагч сэжигтнээр саатуулагдсан.

27. Хүүхдийн амьдрах бүхий л орчинд хүүхдийг зодож шийтгэх явдал хэвээр байгаад Хүүхдийн эрхийн хороо санаа зовниж байгаагаа илэрхийлж, хүүхдийн орчин тойронд сахилга бат хангуулах зорилгоор зодож шийтгэх явдлаас урьдчилан сэргийлсэн хууль тогтоомж батлахыг зөвлөжээ.

28. Гэр бүлийн хүрээн дэх хүчирхийлэл их хэвээр байгаа боловч түүнийг яллах үзүүлэлт бага байгаад Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг устгах хорооноос санаа зовниж байна. Түүнчлэн Монгол Улс гэр бүлийн хүчирхийлэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байгаад харамсал илэрхийлж байна. Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хуулийг хэрэгжүүлэх тал дээр онцгой анхаарал хандуулж, хохирогчид эрх зүйн туслалцаа болон хамгаалалтыг эдлүүлэх боломжоор хангахыг Монгол Улсад хандан Хороо уриалсан.

29. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн дагуу хүчин болон цус ойртолтыг хориглосон заалтууд бүрэн хэрэгжихгүй байгаа бөгөөд гэмт хэрэг үйлдсэн эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийн ял шийтгэл харилцан адилгүй, бэлгийн мөлжлөгт тэр дундаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд шаардлагатай хамгаалалт болон/эсвэл нөхөн сэргээх туслалцаа авч чаддаггүй зарим, тохиолдолд гэмт хэрэгтэнтэй адил харьцах тохиолдолд байдаг Хүүхдийн эрхийн хороо санаа зовниж байна. Монгол Улс хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг хориглож, хүчин болон цус ойртолтын эсрэг арга хэмжээнүүдийг бэхжүүлэхийг Хороо уриалж байна.

30. Хүүхэд эмэгтэйчүүдийг худалдаалах явдлын хүрээ өсөж байгаа боловч түүнийг яллах хувь хэмжээ бага байгаад Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг устгах хороо санаа зовниж байна. Түүнчлэн хохирогчийг нөхөн сэргээх эмчилгээ болон нийгэмшүүлэх механизм байхгүйд Хороо санаа зовниж байна. НҮБ-ын орон хариуцсан баг, Хүүхдийн эрхийн хороо болон Олон улсын хөдөлмөрийн байгууллага мөн адил

тайлбар өгсөн бөгөөд Хүүхдийн эрхийн хороо хүн худалдаалах гэмт хэргийн үндсэн шалтгааныг арилгах үйл ажиллагааг идэвхжүүлэх талаар зөвлөмжиндөө сануулсан. Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс дахь хүний эрхийн төлөв байдлын асуудал хариуцсан тусгай илтгэгч хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нарыг гэмт хэрэгт татан оролцуулахаас сэргийлэх зорилгоор хохирогчийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа зохион байгуулахыг 2010 онд зөвлөжээ. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг устгах хороо үндэсний хяналтын механизмыг агуулсан хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль тогтоомж батлахыг уриалжээ.

31. Хүүхдийн эрхийн хороо бэлгийн мөлжлөгийн тоо ихсэж байгаа, тэр дундаа эмэгтэй хүүхдүүдтэй гэмт этгээдтэй адил харьцдаг, эдгээр хүүхдүүд шаардлагатай хамгаалалтыг авч чаддаггүй, мөн үүнтэй холбоотой мөрдөн байцаах ажиллагаа явагддаггүй бөгөөд гэмт этгээд шийтгэл хүлээдэггүйд санаа зовниж байна. Хороо нь хүүхдийг бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулах, бэлгийн мөлжлөг болон хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хойшлуулушгүй мөрдөн шалгах арга хэмжээ авч гэмт этгээдийг шийтгэх, хохирогчийг хамгаалах болон шаардлагатай нөхөн сэргээх эмчилгээ, нийгэмшүүлэх үйлчилгээгээр хангах болон хохирогчийг эрүүгийн мөрдлөгт татан оролцуулахгүй байх баталгаа өгөх зэрэг зөвлөмжүүдийг Монгол Улсад өгсөн.

32. НҮБ-ын орон хариуцсан багийн мэдээллээр хүүхдийг ашиг олох зорилгоор хурдан морины уралдаан, циркийн үзүүлбэр зэрэгт ашигладаг. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Шинжээчдийн хороо 18 нас хүрээгүй хүүхдийг эрүүл мэндийн аюулгүй байдалд нь хохирол учруулж болох морины уралдаанд оролцуулж байгаа явдалд санаа зовнисон.

33. Хүүхдийн эрхийн хороо хараа хяналтгүй байгаа хүүхдүүдийн тоо өсөж байгаад санаа зовниж, гудамжинд амьдарч байгаа хүүхдүүдийг цагдаагийн албан хаагч нар мөрдөж мөшгиж байгаад харамслаа илэрхийсэн. Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн хороо мөн адил хараа хяналтгүй байгаа хүүхдүүдийн төлөв байдалд санаа зовниж байгаагаа 2000 онд мэдэгдсэн.

### **3. Шударга шүүхээр шийдүүлэх**

34. 2010 онд Эрүүдэн шүүхийн асуудал хариуцсан тусгай илтгэгч өмгөөлөгч байхгүй үед хийсэн мэдэгдлийг шүүх хуралд авч үзэж болохгүй гэж дахин мэдэгдсэн.

35. Тусгай илтгэгч саатуулагдсан хүмүүсийн бүртгэлийг нарийвчлахыг 2008 онд зөвлөж байсан, үүнд саатуулсан газар, цаг, саатуулагдсан этгээдийн эрүүл мэндийн байдал болон саатуулах төвд хийгдсэн зайлшгүй эмчийн үзлэгийн тэмдэглэл орно. Мөн тэрбээр шүүх хурлын өмнө зөвхөн шүүхийн тогтоолоор түр саатуулах түүнчлэн хамгийн эцсийн арга хэмжээ болгон саатуулах, хугацааг аль болох бага байлгахыг зөвлөсөн.

36. Урьдчилан хорих төвд, шаардлагад нийцээгүй нөхцөл байдалд хүүхдүүд саатуулагдаж байгаад мөн цагдаагийн албан хаагч хүч хэрэглэн мэдүүлэг авдаг, ихэвчлэн цагдаагийн хэлтсүүдэд хүүхдийг насанд хүрсэн гэмт хэрэгтнүүдтэй цуг байлгадагт Хүүхдийн эрхийн хороо санаа зовниж байна. Мөн гэмт хэрэгт холбогдсон хүүхдүүдийн асуудал хариуцсан шүүхийн тогтолцоог НҮБ-ын жишигт нийцүүлэн бий болгох тухай

Монгол Улсад өгсөн зөвлөмжөө сануулсан. Шүүх хурлын өмнө хоригдож байгаа хүүхдүүдийн эрхийг хамгаалах, насанд хүрээгүй хүмүүст зориулсан тусгай шүүх байгуулж насанд хүрээгүй хүмүүсийн чиглэлээр мэргэшсэн шүүгч нарыг томилохыг мөн зөвлөсөн.

37. Эрүү шүүлтэд хариуцлага тооцохгүй байгаа нь эрүүдэн шүүхийн үндсэн шалтгаан бөгөөд энэ асуудлаар өргөдөл гомдол хүлээж авах үр дүнтэй механизм байхгүй улмаас гэмт этгээдүүд ял завших буюу хариуцлага тооцохгүй өнгөрөх явдал байгааг Эрүүдэн шүүхийн асуудал хариуцсан тусгай илтгэгч 2005 онд тэмдэглэсэн. Тэрбээр төрийн албан хаагч эрүү шүүлт тулгах явдал байж болохгүй бөгөөд гэмт этгээдэд шүүхийн шийдвэрээр хариуцлага тооцох талаар мэдэгдэл гаргахыг 2008 онд Монгол Улсад зөвлөжээ. Ял завших буюу хариуцлага тооцохгүй байхтай тэмцэхэд бүх талын арга хэмжээ авахыг тэрбээр мөн Монгол Улсад хандан 2010 онд уриалсан.

#### **4. Гэр бүлээрээ амьдрах эрх**

38. Өрх толгойлсон эмэгтэйчүүд өсөлт болон гэр бүлээ толгойлж буй хүүхдүүд, эцэг эхчүүдийн шилжих хөдөлгөөний улмаас гэрт үлдсэн хүүхдүүд зэрэг эцэг эхийн хараа хяналтаас гадуур хүүхдүүдийн шинэ давхарга үүсч буйд Хүүхдийн эрхийн хороо тэмдэглэсэн.

39. Гэр бүлээсээ тусгаарлагдсан хүүхдүүдэд халамжийн өөр хувилбарын үйлчилгээг үзүүлэх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээг тэмдэглэхийн хамт халамжийн байгууллагууд дахь алдаа дутагдал, удирдах ажилтны хайхрамжгүй байдал, орон байрны хүрэлцээгүй байдалд Хүүхдийн эрхийн хороо санаа зовнисон.

40. Хүүхэд үрчилж авах гэр бүлд дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хомсдол болон хүүхэд үрчлэлтийн ажил гүйцэтгэх, зохицуулах, хянаж шалгах механизм дутагдалтай байгаад Хүүхдийн эрхийн хороо нь тухайлбал мөн санаа зовнисон. Хүүхэд үрчлэлт болон асран хамгаалах талаар үндэсний цогц бодлого боловсруулж, Улс хооронд хүүхэд үрчлэхэд хүүхдийн эрхийг хамгаалах, хамтран ажиллах тухай Гаагын конвенцийг хэрэгжүүлэх үүрэг бүхий үндэсний эрх бүхий байгууллага байгуулахыг Хүүхдийн эрхийн хорооноос Монгол Улсад зөвлөмж болгосон.

41. Дотоодын шилжилт хөдөлгөөн, төрснийг бүртгэх газрын алслагдмал байдал болон төрсний бүртгэлийн ач холбогдлын талаарх малчин айл өрхүүдийн дундах мэдлэг дутмаг зэргээс үүдэн төрөлтийн арав орчим хувь нь албан ёсоор бүртгүүлээгүй байгаад Хүүхдийн эрхийн хороо санаа зовнисон хэвээр байна.

#### **5. Шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, олон нийтийн болон улс төрийн амьдралд оролцох эрх**

42. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Шинжээчдийн хороо нь улс төрийн үзэл бодлын хүрээнд төрийн албан хаагчдыг халах явдал их хурлын буюу орон нутгийн сонгуулийн дараа тогтмолжих хандлагатай байгааг 2008 онд тэмдэглэж, үүнийг Засгийн газраас 2010 нотолсон. Үзэл бодлын улмаас төрийн албан хаагчдыг ажлаас нь халах явдлыг таслан зогсоох талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл ирүүлэхийг Монгол Улсаас хүссэн.

43. Шийдвэр гаргах албан тушаал хашиж байгаа ялангуяа өндөр түвшний шийдвэр

гаргах албан тушаалд буюу Парламентад байгаа эмэгтэйчүүдийн төлөөллийн түвшин доогуур буюу буурч байгаа, мөн намуудаас буюу эвслээс нэр дэвшигчдийн 30 хувь эмэгтэйчүүд байхаар квот тогтоосон заалт бүхий хууль танилцуулсан ч түүнийг 2007 онд Парламент хүчингүй болгосонд Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг устгах хороо нь санаа зовнисон. Сурч боловсрох эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч хүйсийн тэгш байдал болон олон нийтийн харилцаанд эмэгтэйчүүдийн оролцоо дутмаг байгааг тэмдэглэсэн байна. Тэрбээр хүйсийн тэгш бус уламжлалт байдлаас татгалзах хэрэгцээ шаардлагыг онцлон дурдсан бөгөөд дан ганц сургууль дээр ч бус нийт хүн амын дунд ч хүний эрхийн соёлыг бий болгохын ач холбогдлыг тусгасан байна.

#### **6. Хөдөлмөрлөх эрх, ажлын таатай нөхцөлөөр хангагдах эрх**

44. Нэгдсэн Үндэстний Байгууллагын орон хариуцсан баг нь одоогийн төрийн болон хувийн хэвшил дэх хамгийн доод цалингийн хэмжээ нь амьдралаа залгуулахад хүрэлцэхээргүй байгааг тэмдэглэсэн байна. Эрүүл мэнд, аюулгүй байдлын стандарт, ялангуяа барилга, уул уурхайн салбарт хангалтгүй.

45. Хөдөлмөр эрхлэлтийн насны доод хязгаар нь заавал эзэмших боловсролын шатны сургуулийн наснаас доогуур байх ёсгүйг тэмдэглэхийн хамт Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Шинжээчдийн хороо нь Монгол Улсаас хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарыг (15 нас) заавал эзэмших боловсролын шатны сургуулийн настай (17 нас) ойртуулан нэмэхийг хүсэлт болгосон.

46. Хүүхдийн эрхийн хороо нь хүүхдийн хөдөлмөрийн өсөлт тухайлбал уул уурхай, цирк, хөдөө аж ахуй болон хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд, тэдгээрийн илрэлийг харуулсан тайланд санаа зовнисон. Түүнчлэн Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Шинжээчдийн хороо нь аюултай ажил хийж буй 15 хүрэхгүй настай хүүхдүүдийн тоо их байгааг тэмдэглэсэн байна. Цаашлаад аюултай ажил хийж буй хүүхдүүдийн ажил эрхлэлттэй холбоотойгоор ногдуулсан шийтгэлүүд сул байгааг ч тэмдэглэсэн байна.

47. Зарим хүүхэд хот орон нутагт албан бус эдийн засгийн салбарт ажил хийж байгаа тухай мэдээлэл бүхий тайланг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Шинжээчдийн хорооноос эшлэж, албан бус эдийн засгийн салбарт ажиллаж байгаа буюу өөрсдийн хэрэгцээгээ хангаж буй хүүхдүүдийг хамгаалахыг хүссэн.

#### **7. Амьдралын баталгаажих түвшин ба нийгмийн хамгааллын эрх**

48. Арьс үндсээр ялгаварлан гадуурхах явдлыг устгах хороо нь эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хэрэгжилт хөдөөний буюу алслагдмал нутаг дэвсгэрт харилцан адилгүй байх, ялангуяа угсаатны бүлгүүдэд нөлөөлж буйд санаа зовнисон. Арьс үндсээр ялгаварлан гадуурхах явдлыг устгах хороо хэрэгцээтэй газарт нь шаардлагатай нөөцөөр шууд хангахыг Монгол Улсад хандан уриалсан.

49. Хоол хүнсний хүртээмжтэй байдал нь үндэсний хэмжээнд зохих түвшинд байгаа ч хотын зарим айл өрхүүд ажилгүйдлээс үүдэлтэйгээр хот газрын зарим гэр бүл хэрэгцээт хүнсээ хүртэж чадахгүй байгаад НҮБ-ын орон хариуцсан баг тэмдэглэсэн. Тухайлбал эрс тэс цаг агаарын өндөр эрсдлийн улмаас малчид, тариаланчдад илүү эмзэг байдал үүсч,

улмаар хөдөө орон нутгийн хүн амын хооллох эрхэд илүү хүндээр туссан.

50. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага өнгөрсөн жилүүдэд тохиолдсон хүнсний баталгаат бус байдал, хүнснээс үүдэлтэй өвчлөлтүүдийн онцгой тохиолдлуудыг тэмдэглэж, хүнсний микробиологийн болон химийн бохирдлын талаар санаа зовниж буйгаа илэрхийлсэн.

51. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас Монгол Улс нь хот, хөдөө дэх Эхийн эндэгдлийн харьцаа (ЭЭХ) дахь олон өөрчлөлтийг харуулсан тогтвортой бууралтыг хянаж байна гэж тэмдэглэсэн байна. Зарим алслагдмал аймгуудад, ЭЭХ зургаан төрөлт тутамд дөрөв байсан бол Улаанбаатар хотод харьцангуй бага байжээ. Нэгдсэн Үндэстний Байгууллагын орон хариуцсан баг мөн адил дүгнэлт хийсэн. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг устгах хороо нь хөдөө орон нутгийн эмэгтэйчүүд, мөн доогуур орлоготой бүлгийн эмэгтэйчүүд нь төрөлт болон жирэмсний хүндрэлээс болж нас баралт их байгаад санаа зовниж буйгаа илэрхийлсэн.

52. Хоол тэжээлийн дутагдал буюу тэжээлийн бичил элементийн дутагдлаас хамаарах нярайн сульдаа (рахит) болон эндэгдэл ялангуяа 5 хүртэлх насны эрэгтэй хүүхдийн дунд элбэг байгаад Хүүхдийн эрхийн хороо санаа зовниж буйгаа илэрхийлсэн. ДЭМБ нь адил судалгаануудыг хийжээ. Энэ нь тухайлбал хоол тэжээлийн дутагдал өндөр хувийг эзэлж байгааг харуулж байна. ДЭМБ-аас Монгол Улс бол Баруун Номхон далайн бүс дэх долоо дахь хамгийн өндөр сүрьеэгийн тархалттай орон гэж тэмдэглэсэн байна.

53. Монгол Улс эрүүл мэндийн үндэсний хэмжээний цогц бодлого боловсруулж хэрэгжүүлэх замаар хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах хүч чармайлт гаргаж буй хэдий ч хот хөдөөгийн хүн амын дундах эрүүл мэндийн ялгааг харуулсан хэд хэдэн гол төвөгтэй асуудал, тухайлбал эрүүл мэндийн салбарт ажиллах хүчний хуваарилалт, урьдчилан сэргийлэлт, яаралтай түргэн тусламж болон гамшигийн үеийн бэлэн байдалд анхаарал хандуулахыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага тэмдэглэсэн байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ нь ялангуяа хөдөө орон нутагт хязгаарлагдмал байгаад Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг устгах хороо санаа зовниж буйгаа илэрхийлсэн. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг устгах хорооноос Монгол Улсыг эрүүл мэндийн дэд бүтцээ сайжруулах оролдлогоо үргэлжлүүлэх, мөн эрүүл мэндийн үйлчилгээ хүртээмжтэй байхад зориулж хангалттай төсвийн хуваарилалт хийхийг уриалсан байна.

54. Нэгдсэн Үндэстний Байгууллагын орон хариуцсан багаас хангалттай ус болон ариутгах хэрэгслүүдээр хангагдсан эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх газар, дунд болон бага орлоготой хүмүүсийн хувьд дутагдалтай байгааг онцлон тэмдэглэжээ. Улаанбаатар хотод оршин суугчдын 78 хувь нь ундны ус ба бохир усны холболтгүй гэрт амьдардаг байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас сургууль болон эрүүл мэндийн тусламж үзүүлдэг байгууллагууд дахь усны баталгаат байдал болон усны ариун цэврийн байдлын талаарх зохицуулалтын асуудал гол бэрхшээл болж буйг тэмдэглэсэн. Түүнчлэн цэвэр ус хүртэх болон усны ариун цэврийн асуудал дээр хот хөдөөгийн хооронд томоохон ялгаа байгааг, нүүдэлчин айл өрхийн хүүхдийн суралцаж буй сургууль, дотуур байр усны баталгаатай эх үүсвэр ба хүрэлцэхүйц цэвэр усаар дутагддаг талаар дурдсаныг Нэгдсэн Үндэстний Байгууллагын орон хариуцсан баг Мянганы хөгжлийн зорилтуудын



хэрэгжилтийн тухай 2009 оны үндэсний илтгэлээс эшлэл хийн тэмдэглэсэн. Хүүхдийн эрхийн хороо нь эрүүл ахуйн байдлыг сайжруулах, ундны усны аюулгүй байдалд хандах хандлагыг нэмэгдүүлэх талаар авч буй арга хэмжээгээ бататгахыг зөвлөмж болгосон.

55. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хөдөө орон нутгаас томоохон хотууд руу шилжих хөдөлгөөн ихэссэний улмаас борчуулын хороолол (өөрөөр “гэр хороолол” гэж нэрлэдэг) хэт ачаалалтай болж ажилгүйдэл, эрүүл мэндийн үйлчилгээ хязгаарлагдах, усны ариун цэврийн хангамж алдагдаж хэрэглээгээ гүйцэхгүй байна гэж тэмдэглэсэн байна.

56. Хүүхдийн эрхийн хороо нь ядуурлын тархалтын асуудлыг хөндсөн байна. Нэгдсэн Үндэстний Байгууллагын 2007–2011 оны Хөгжлийн албан ёсны тусламжийн хүрээний баримт бичигт дурдсаны дагуу хүн төрөлхтний ядуурал нь хүүхдийн хөдөлмөр, гудамжны хүүхдүүд буюу гэр оронгүйчүүд, хүний наймаа зэргийг үүсгэх гол шалтгаан болж буй бөгөөд улмаар амиа хорлох явдлыг түгшүүртэй хэмжээнд нэмэгдүүлэх үндэс суурь болж байна. Эмэгтэйчүүдийн дундах ядуурал өндөр байгаа бөгөөд ядуурлыг бууруулах стратеги нь эмэгтэйчүүдийн эрхэд хангалттай хэмжээнд анхаарал хандуулаагүйгээс хэрэгжээгүйд Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг устгах хороо санаа зовниж буйгаа илэрхийлсэн.

## **8. Нийгэм соёлын амьдралд оролцох ба сурч боловсрох эрх**

57. Нэгдсэн Үндэстний Байгууллагын орон хариуцсан баг 2009 онд ерөнхий болон суурь боловсролын сургуульд хамрагсад 93.5 болон 91.2 тус тус хүрч, их дээд сургуульд суралцагсдын түвшин сүүлийн таван жилд тогтвортой байна. Сурч боловсрох эрхийн асуудал хариуцсан тусгай илтгэгч сургуулийн элсэлтийн хэмжээ өндөр байгааг онцолж, их дээд сургууль буюу боловсролын байгууллагууд дахь элсэлтийн харьцаа 2007 онд бүсийн дунджаас хоёр дахин их буюу 48 хувьд хүрснийг цохон тэмдэглэсэн байна.

58. Тусгай илтгэгч анхан болон дунд ангиас завсардсан хүүхдүүдийн харьцааны тухай тодорхой дурдсан байна. Сургуулиа хаясан тэдгээр хүүхдүүдийн ихэнх нь хөвгүүд гэдэг нь албан бус мэдээ бөгөөд сургуулиас завсардсан хүүхдүүдийн тоо яг тодорхой бус байна. Хүүхдийн эрхийн тухай конвенц нь сургуулиас завсардсан тооны харьцаанд хөвгүүд илүү байгаа буюу боловсрол олгоход хөвгүүд бага оролцож байгаад санаа зовнисон.

59. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Шинжээчдийн хороо нь малчин айлын хүүхдүүд мал дээр гарч гэр бүлдээ тусалж буй малчдын хүүхдүүдийн сургуулиас завсардах харьцаа өндөр байгааг харуулсан 2005–2006 онд явуулсан судалгааг харуулсан байна. Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн хороо 2000 онд мөн адил дүгнэлт хийсэн.

60. Нэгдсэн Үндэстний Байгууллагын орон хариуцсан багийн дурдсанаар казахчуудын өлгий нутаг Баян-Өлгий аймагт сургууль завсардалт хамгийн өндөр байгаа бөгөөд сургуулийн өмнөх боловсролд хамрагдах түвшин улсдаа хамгийн доогуур байна. Түүнчлэн хүн амын цөөнх болох тува ястангуудын хүүхдүүд боловсролын аль ч түвшинд хязгаарлагдмал оролцоотой байгааг тэмдэглэсэн байна.

61. Боловсролын үйлчилгээ хүртэх боломж хүүхдүүдийн хувьд, ялангуяа алслагдмал хөдөө орон нутгийн малчдын хүүхдүүд, нийслэл хот уруу шилжин суурьшсан айлуудын

хүүхдүүд, уул уурхайд ажиллаж буй хүүхдүүд зэрэг сургуулийн өмнөх боловсролын түвшинд хязгаарлагдмал байгаад Хүүхдийн эрхийн хороо санаа зовниж буйгаа 2010 онд илэрхийлсэн. Нэгдсэн Үндэстний Байгууллагын орон хариуцсан баг түүнчлэн малчдын хүүхдүүдэд зориулан нүүдлийн “гэр” цэцэрлэг байгуулсан хэдий ч цэцэрлэгт нийт хүүхдийг хамруулахад бэрхшээлтэй хэвээр байгааг мөн тэмдэглэсэн.

62. Сурч боловсрох эрх хариуцсан тусгай илтгэгч сургуулийн барилга болоод дотуур байрны нөхцөл байдал хангалтгүй байгааг тэмдэглэсэн. Хөдөө орон нутагт ус, усны ариун цэврийн асуудал нэмэгдсэн бөгөөд хот суурин газрын сургуулиудын тулгамдсан асуудал нь хөдөөнөөс хот уруу чиглэсэн дотоодын шилжин суурьших хөдөлгөөний үр дүнд улам бүр ихэссээр байна.

63. Боловсролын хөтөлбөрүүдэд хүний эрхийн үзэл баримтлалыг тусгах зайлшгүй шаардлагатайг тусгай илтгэгч тэмдэглэсэн. Хэдийгээр хүний зарим эрхүүд нь хөтөлбөрийн зарим хэсэгт багтсан ч тэдгээр нь тодорхой өнгөцхөн дурдагдсан байна. Нөөц боломж хомс ч багш нарыг давтан мэргэшүүлэх Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн санаачилгыг тэрбээр онцолсон байна. Тэрээр хүний эрхийн чиглэлээр монгол хэл дээрх ном товхимол байхгүй байгааг тэмдэглэсэн. Хүүхдийн эрхийн хороо нь Монгол Улсаас хүний эрхийн чиглэлээр хичээл сургалтыг сургуулийн боловсролын хөтөлбөрт тусгаагүйд анхаарал хандуулахыг зөвлөмж болгосон. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг устгах хороо мөн адил зөвлөмж өгсөн.

### **9. Хүн амын цөөнх буюу уугуул иргэд**

64. Хүүхдийн эрхийн хороо нь Баруун бүсийн буюу казах болон бусад цөөнхийн хүн амын дундах тэгш бус байдалд санаа зовнисон. Арьс үндсээр ялгаварлан гадуурхах явдлыг устгах хороо нь угсаатны тодорхой бүлгийн эдийн засаг, нийгэм, соёлын түвшин доогуур байгаа нь хэдийгээр Засгийн газраас хэрэгжүүлсэн хүч чармайлтын шууд үр дүн биш ч гэсэн үнэндээ ялгаварлан гадуурхалтын илэрхийлэл байна гэж үзсэн.

65. Арьс үндсээр ялгаварлан гадуурхах явдлыг устгах хороо нь цагдаагийн байгууллага дахь цөөнхийн бүлгүүдийн төлөөлөгчдийн түвшин бага байгаад санаа зовниж, төрийн байгууллагууд болон төрийн удирдах албан тушаалд угсаатны цөөнхүүдийн төлөөллийг байршуулах талаар арга хэмжээ авахыг зөвлөсөн.

66. Тува хэлний сургалтын хөтөлбөрийг 2005 онд баталсан ч үндэстний цөөнхийн хэлний дадлагажуулах арга хэмжээнүүд байхгүй байгаад Арьс үндсээр ялгаварлан гадуурхах явдлыг устгах хороо нь 2006 онд санаа зовниж буйгаа илэрхийлсэн ба Монгол Улсад албан ёсны хэлний хажуугаар үндэстний цөөнх уугуул хэлнийхээ бүтцийг судлах, соёлын болон боловсролын бодлогыг сайжруулахад тэдний оролцоог дэмжихийг санал болгожээ. Сурч боловсрох эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч анхан шатны түвшинд казах үндэстнийг хос хэлний (монгол–казах) боловсролтой болгохыг 2010 онд дурдсан бөгөөд Монгол Улсыг сургалтын хөтөлбөр ба казах хэл дээр номнуудыг идэвхтэй боловсруулахыг тэмдэглэжээ.

#### **10. Шилжин суурьшигчид, дүрвэгсэд буюу улс төрийн орогнол эрэгсэд**

67. Арьс үндсээр ялгаварлан гадуурхах явдлыг устгах хороо Монгол Улс нь улс төрийн орогнолын асуудлаар хууль хараахан батлаагүй бөгөөд дүрвэгчдийн статусыг тодорхойлох үйл ажиллагааг тусгаагүй, шүүхийн хамгаалах хэрэгсэл, эрх зүйн туслалцаа, аман орчуулгын үйлчилгээ, улс төрийн орогнол хүсэж байгаа хүмүүсийг мэдээллээр хангах зэрэг баталгаа олгохыг зөвлөжээ.

68. Бүгд Найрамдах Солонгос Ард Улсын хүний эрхийн төлөв байдлын асуудал хариуцсан тусгай илтгэгч эх оронд нь албадан буцаахгүй байх зарчим мөрдөгдөж байгааг тэмдэглэжээ. Монгол Улсын хувьд энэхүү зарчим нь Хүний эрхийн Дээд комиссарын газрын 1951 онд конвенцид нэгдэхээс өмнө эх оронд нь албадан буцаахын эсрэг хангалттай баталгаа байхгүй байсан.

69. 2008 онд Тусгай илтгэгч өмнөх айлчлалаасаа хойш орогногчдыг байрлуулах газрын нөхцөл байдалд бодитой дэвшил гарсан гэж тэмдэглэжээ. 2008, 2010 онуудад Монгол Улсыг улс төрийн орогнол хүссэн хүмүүстэй хүнлэг хандах бодлогыг үргэлжлүүлэх, тэр дундаа бие бялдар болоод сэтгэл санааны хэрэгцээг хангасан, мөн хэл болон бусад орнуудад дасан зохицох хэрэгцээг хангаж өгөхийг зөвлөжээ.

#### **11. Хөгжих эрх**

70. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Туслах Тогтолцооны дагуу, Монгол Улс газар зүйн байрлалаараа далайд гарцгүй, хүн ам нь цөөн тархай бутархай сийрэг, хахир хатуу цаг уурын нөхцөл зэрэг эмзэг байдлуудыг чухалчилж байна. Эдгээр асуудлын ихэнх нь бүс нутгийн хамтын ажиллагаа болон Мянганы хөгжлийн зорилтын 8 дахь зорилтын хүрээнд шийдэгдэх боломжтой юм.

### **III. Ололт, тэргүүн туршлага, хүндрэл болон бэрхшээлүүд**

71. Хүний эрхийн Дээд комиссарын газрын зүгээс Монгол Улсын цаазаар авах ялыг түдгэлзүүлэх шийдвэрийг сайшаасан ба Монгол Улсын энэхүү алхам Азид манлайллын жишээ болж тэмдэглэгдсэн.

72. НҮБ-ын орон хариуцсан багийн тэмдэглэснээр, Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн туслах тогтолцоог дэмжиж Мянганы хөгжлийн 9 дэх зорилтыг баталсан.

73. Урьдын адил ихэнх шилжин суурьшигчдын бүртгэлгүй байгаа бөгөөд тэдний тогтвортой бус байдал, хот хоорондын шилжилт хөдөлгөөн нь Засгийн газарт нийгэм, эдийн засаг болон эрүүл мэндийн ноцтой хүндрэл бэрхшээлүүдийг үүсгэдэг гэж Дэлхийн эрүүл мэндийн байгууллага тэмдэглэсэн. Хөдөө орон нутгийн нүүдэлчдийн амьдралын хэв маяг, алслагдсан, тархай бутархай суурьшсан хүн ам, хол зай нь нийгмийн үр ашигтай хангамж хүргэхэд бэрхшээл болдог.

74. Монголчууд газар хөдлөлт, үер, зуд зэрэг байгалийн гамшигт өртөмтгий гэж Дэлхийн эрүүл мэндийн байгууллага тэмдэглэжээ.

**IV. Үндэсний тэргүүлэх чиглэл, санаачлагууд болон хүлээсэн үүргүүд Хэрэгжилтийг хангах тусгай зөвлөмжүүд**

75. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг устгах хороо Монгол Улсад өгсөн жендэрийн тэгш байдлын тухай хуулийн төслийн хүрээнд болон эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш байдлыг хөхиүлэн дэмжих механизмыг бий болгох зөвлөмжийг биелүүлэхийг зөвлөжээ. Хэрэгжилтийн талаарх мэдээллийг 2010 онд хүргүүлсэн байх ёстой.

**V. Чадавхыг бэхжүүлэх болон техникийн тусламж**

76. Хүүхдийн эрхийн хороо Монгол Улс НҮБ-ын хүүхдийн хүчирхийллийн эсрэг асуудлаар, насанд хүрээгүй хүмүүсийн шүүх хурлыг зохион байгуулах болон цагдаагийн албан хаагчийг бэлтгэх асуудлаар, хүүхдийн хөдөлмөрийн сөрөг нөлөө түүнд хориг тавих, Палермогийн протокол болон үндэсний хууль зүйн тогтолцоонд хууль зүйн шинжилгээ хийх зорилгоор НҮБ-ын байгууллагуудад техникийн туслалцаа авах зорилгоор хандахыг зөвлөсөн.

## 9.4 МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТАЛААРХ ҮНДЭСНИЙ ХОЁРДУГААР ИЛТГЭЛ

### I. ТАНИЛЦУУЛГА

1. Монгол Улс Хүний эрхийн төлөв байдлын талаарх Үндэсний анхдугаар илтгэлийг 2010 онд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл (цаашид “ХЭЗ” гэх)-ийн 16 дугаар чуулганаар хэлэлцүүлсэн. Хэлэлцүүлгийн дүнд бусад улс орноос давхардсан тоогоор нийт 129 зөвлөмж өгсний 126 зөвлөмжийг Монгол Улс биелүүлэхээ зөвшөөрч, гурван зөвлөмжийг биелүүлэх боломжгүй болохоо мэдэгдсэн.

### II. ИЛТГЭЛ БОЛОВСРУУЛАХ АРГА ЗҮЙ, ЗӨВЛӨЛДӨХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2. Үндэсний хоёрдугаар илтгэлд 2010–2014 онд Монгол Улсад хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих чиглэлээр гарсан эрх зүйн болон бүтцийн өөрчлөлт, дэвшил, Монгол Улсын Засгийн газар (цаашид “МУЗГ” гэх)-аас 2011 онд баталсан ХЭЗ-ийн зөвлөмжийг 2011–2014 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг тусгав. Монгол Улс зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх дунд хугацааны сайн дурын илтгэлийг НҮБ-д 2014 оны 5 дугаар сард хүргүүлсэн. Түүнчлэн хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд учирч буй хүндрэл, бэрхшээл, тэдгээрийг даван туулах арга зам, зорилтын талаар тусгав.

3. Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулсан Үндэсний хоёрдугаар илтгэлийг боловсруулах ажлын хэсэг зөвлөмжийн зохих хэсгийн хэрэгжилтийн тайланг холбогдох байгууллагаас гаргуулан авч, нийт хоёр удаа хуралдсан. Түүнчлэн Монгол Улсын яам, агентлаг, Хүний эрхийн үндэсний комисс (цаашид “ХЭҮК” гэх), хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага (цаашид “ТББ” гэх)-тай хамтран илтгэлийн нээлттэй хэлэлцүүлгийг гурван удаа зохион байгуулав.

4. Илтгэлд дээрх хэлэлцүүлгийн үеэр ТББ-уудын төлөөлөл, оролцогчдоос өгсөн санал, зөвлөмжийг тусгав.

### III. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ, ХӨХИҮЛЭН ДЭМЖИХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

#### A. Үндэсний эрх зүйн орчин сайжруулах

5. Монгол Улсад хүний эрхийн асуудлыг хариуцсан, үүрэг хүлээсэн механизм нь УИХ-ын Хүний эрхийн дэд хороо /ХЭДХ/, Хүний эрхийн үндэсний комисс /ХЭҮК/, Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөрийг /ХЭХҮХ/ хэрэгжүүлэх Хороо, түүний ажлын алба болон аймаг нийслэл дэх салбар хороодоос бүрдэнэ.

6. Шүүхийн шинэчлэлийн хүрээнд Монгол Улсын шүүхийн тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай, Шүүхийн захиргааны тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулиуд 2013 онд батлагдсан.

7. Улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилгоор Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг 2011 онд батлав. Хуулиар жендэр, жендэрийн тэгш байдал, бэлгийн дарамт, хүйсийн төлөөллийн доод хязгаар (квот)–ыг бий болгож, улс төр, эдийн засаг, нийгмийн бүх харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эрхтэй байх, ялгаварлан гадуурхагдахгүй байх, төрийн болон ТББ–д баримтлах хүйсийн төлөөллийн доод хязгаарыг хуульчлан тогтоов. Жишээлбэл, яам, агентлагийн бүтцийн нэгжийн дарга нарын 15–аас доошгүй хувь нь эмэгтэйчүүдийн төлөөлөл байхаар зохицуулсан. Хууль сахиулах салбарын хэмжээнд нийт 22191 албан хаагчид ажиллаж байгаа бөгөөд 84.2 хувь нь эрэгтэй, 15.8 хувь нь эмэгтэй албан хаагчид ажиллаж байна. Хууль зүйн яамны харьяа агентлаг, байгууллагуудын дээд шатны удирдлагуудын хүйсийн тэнцвэрт байдлыг авч үзвэл 31 дээд шатны удирдах албан тушаалтан байгаагаас 29 буюу 90.3% нь эрэгтэй, 2 буюу 6.5% нь эмэгтэй байна.

8. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг 2012 онд батлан, хүн ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай Палермогийн протоколд нийцүүлэн хүн худалдаалах гэмт хэргийг тодорхойлсон. Хүн худалдаалах гэмт хэргийн ойлголт, хор уршиг, урьдчилан сэргийлэх, тайлбарлан таниулах талаарх асуудлыг ерөнхий боловсролын сургуулийн ахлах, дунд ангийн сургалтын хөтөлбөрт тусгах, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, алдар хүндийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах зорилгоор түүнтэй холбоотой мэдээллийг нууцлах, хамгаалах байр ажиллуулах, хохирогчдод эрүүл мэндийн болон сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ үзүүлэх, ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах, хууль зүйн туслалцаа үзүүлэх үүргийг төр хүлээх зэрэг зохицуулалтыг энэ хуулиар тогтоосон.

9. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг 2013 онд батлав. Энэ хуулиар амь нас, эрүүл мэндэд нь хохирол учирч болзошгүй, эсхүл хохирол учирсан гэрч, хохирогчийг хамгаалах биечилсэн хамгаалалт, аюулгүй газарт түр байрлуулах, гадаад төрхийг өөрчлөх зэрэг хамгаалалтын арга хэмжээний хэлбэрийг тодорхойлж, хамгаалалтын арга хэмжээг хамгаалах нөхцөл байдал үүссэн үед авч хэрэгжүүлэх үүргийг цагдаагийн алба, мөрдөх алба, Тахарын алба, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газарт хүлээлгэсэн.

10. Төлбөрийн чадваргүй яллагдагчид эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хууль нь 2013 онд батлагдаж ядуу иргэдийг хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахаар мөрдөх ажиллагаа болон гэмт хэргийг шүүхээр хянан шийдвэрлэхэд өмгөөлөгчөөр оролцох зэргээр эрхийг нь хамгаалж байна.

### **В. Олон улсын гэрээнд нэгдэн орсон байдал**

11. Монгол Улс тайлангийн хугацаанд зөвлөмжид туссан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын Цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт II протоколд (2012) нэгдэн орж, Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенц (2014) болон Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколыг (2014) тус тус соёрхон батлав.

12. Монгол Улс Иргэний эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын

пактын 4 дүгээр илтгэлийг 2012 онд, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн анхдугаар илтгэлийг 2012 онд, Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенцийн 19–21 дүгээр илтгэл (нэгтгэсэн)–ийг 2014 онд, Эмэгтэйчүүдийг алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн 8–9 дүгээр илтгэл (нэгтгэсэн)–ийг 2014 онд тус тус хүргүүлсэн. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 5 дугаар илтгэл, Эрүүдэн шүүх болон хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн 2 дугаар илтгэлийг боловсруулсан.

### **С.Хүний эрхийг хангах чиглэлээр шинээр байгуулагдсан институцууд**

13. Анхдугаар тайланд дурдсан хүний эрхийн байгууллагууд үйл ажиллагаагаа явуулж байгаагийн зэрэгцээ тайлангийн хугацаанд батлагдсан Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Тахарын албаны тухай хуулийн дагуу гэрч, хохирогчийг хуульд заасан хэлбэрээр хамгаалах үүрэг бүхий Тахарын албыг шинээр байгуулан ажиллуулж байна. Тахарын алба нь 79 шүүхийн 41 Тамгын газрын 43 байрыг хамгаалалтанд аваад байна.

14. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлогын зөвлөлийг 2012 онд байгуулав.

15. Хүний эрхийн чиглэлээрх олон улсын гэрээнд нэгдэн орох, орсон гэрээний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, гэрээний тайлан, мэдээллийг боловсруулах, хүргүүлэх ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий Хүний эрхийн хэлтсийг Гадаад хэргийн яамны Олон улсын эрх зүйн газарт 2014 онд шинээр байгуулав.

16. Төлбөрийн чадваргүй яллагдагчид эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хууль батлагдсанаар Хууль зүйн туслалцааны төвийг улсын хэмжээнд байгуулан нийслэлийн 9 дүүрэг, 21 аймаг болон 3 суманд төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг явуулж байна. Хууль зүйн туслалцааны төвд 2014 оны эхний хагас жилд нийт 982 хэргийн 1046 холбогдогч үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ авахаар хандсанаас 479 хэргийг шүүхээр бүрэн шийдвэрлэж, шүүхийн өмнөх шатанд 66 хэргийг шийдвэрлэн, 358 хэрэг шийдвэрлэх шатанд байна. Үйлчлүүлэгчдийн дийлэнх хувь нь мөрдөн байцаалтын (49.2%) болон анхан шатны шүүхийн шатнаас (28.3%) өмгөөллийн туслалцаа авахаар хандсан байна.

### **Д. Шүүхийн шинэчлэл**

17. Шүүхийн шинэ багц хуулийн зорилго нь шүүхийн шинэтгэлийн амин чухал асуудлууд болох шүүхийн бие даасан, нээлттэй, ил тод байдлыг хангах, шүүхийн захиргаа, төсвийг бие даалгах, шүүх, шүүгчийн ажлын ачааллыг зохистой болгох, шүүгчийн ур чадвар, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх замаар шударга шүүхээр шийдвэрлүүлэх Монгол Улсын ардчилсан Үндсэн хуульд заасан шүүх эрх мэдлийн зарчмыг илүү бодитойгоор хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх юм.

18. Шүүхийн тухай багц хууль 2013 оны 4 сарын 15–аас хэрэгжснээр дараах үр дүн гарч байна. Үүнд: Шүүхийн захиргаа, шүүн таслах ажиллагааг тус тусад нь салгаж, шүүгчийг захиргааны удирдлага, нөлөөллөөс ангид байх нөхцөлийг бүрдүүллээ. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, хамгаалах чиг үүрэг бүхий Шүүхийн ерөнхий зөвлөлийг бүтэц, зохион байгуулалтын хувьд анх удаа бие даасан загвараар

байгуулав.

19. Анхан болон давж заалдах шатны шүүхүүдийг дагнасан хэлбэрээр бүсчлэн байгуулж, шүүгч шүүн таслах ажлын төрлөөр дагнан мэргэшэх боломж бүрдлээ. Шүүгчийн хараат бус, бие даасан байдлыг хангах, шинэ механизмуудыг хэрэгжүүлж, үйлчилж эхэлсэн.

20. Шүүхийн тухай багц хуулиар технологийн ололт, шийдлийг нэвтрүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсний дагуу бүх шатны шүүхийн байранд “НЭЭЛТТЭЙ ШҮҮХ” танхим байгуулан, шүүх хуралдааны явцыг шууд үзэх нөхцлөөр бүрдүүлэн шүүхийн үйл ажиллагааг иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод байх хуулийн заалт бодитой хэрэгжиж байна. Ингэснээр шүүхийн шатанд хүний эрх зөрчигдөхөөс хамгаалах механизм бүрдэж байна.

21. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа манай улсад 2014 оноос хэрэгжиж одоогоор Иргэний хэргийн анхан шатны 33 шүүх дээр эвлэрүүлэн зуучлах ажиллагааг амжилттай явуулж байна.

22. “Шүүхийн иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах, ажиллуулах журам”-ын дагуу иргэдийн төлөөлөгчид анхан шатны шүүхүүдэд ажиллаж байна.

#### **IV. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ, ХӨХИҮЛЭН ДЭМЖИХ ХҮРЭЭНД ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙДАЛ**

##### **А. Цаазаар авах ялыг халах чиглэлээр**

23. “Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын Цаазаар авах ялыг халах тухай II протокол”-ыг 2012 оны 1 дүгээр сарын 5-нд соёрхон баталсан.

24. Монгол Улсын Ерөнхийлөгч Эрүүгийн хуульд заасан хэмжээ хязгаарын хүрээнд ял эдэлж байгаа ялтанд уучлал үзүүлэх бүрэн эрхийн дагуу 2010 онд цаазаар авах ялаас түдгэлзэж, энэ хугацаанд нэг ч хүн цаазаар авахуулаагүй байна.

25. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад цаазаар авах ялыг хасахаар тусгасан.

26. Хууль, тогтоомжид заасан стандарт шаардлага хангасан, 24 цагаар хяналт тавьдаг хөдөлгөөнт телекамераар тоноглогсон өрөө бүхий шинээр ашиглалтад оруулсан цагдан хорих төвд цаазаар авах ялтай этгээдийг хорих нөхцлийг бүрдүүлэв.

27. Цаазаар авах ялтай этгээдтэй Олон улсын стандартад нийцүүлэн харьцаж байгаа эсэхэд Прокурорын байгууллага эрх хэмжээнийхээ дагуу хяналт тавьж ажилладаг.

##### **В. Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр**

28. Монгол Улс “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг НҮБ-ын конвенцийн Нэмэлт Протокол”-д 2013 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр гарын үсэг зурж, 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдөр соёрхон баталсан.

29. 2013 онд батлагдсан Цагдаагийн албаны тухай хуулиар цагдаагийн алба, албан хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавих эрхийг ХЭҮК-т олгосон. Ингэснээр цагдаагийн албан хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавих хараат бус үндэсний тогтолцоо бүрдэж байна.



30. Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг цагдаагийн байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх, түүний биелэлтийг хангуулж, дээд шатны байгууллагад танилцуулах үүрэг бүхий салбар хороог байгуулсан. Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд даргаар ахлуулсан тус салбар хороо нь хүний эрхийг хангах ажлын хүрээнд болон “Цагдаагийн ерөнхий газар болон Хүний эрхийн үндэсний комиссын хамтран ажиллах санамж бичиг”-ийн хүрээнд зохион байгуулсан ажил, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, эрүүгийн хэрэгт цагдан хоригдсон хүмүүсийн талаарх судалгаа, цагдан хоригдсон сэжигтэн, яллагдагч нараас хүний эрхийн талаар гаргасан гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлт болон цаашид хүний эрхийг хангах ажлын хүрээнд дэвшүүлэх зорилт, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэлэлцсэн хурлыг зохион байгуулж хэвшсэн.

31. Хууль зүйн сайдын тушаалаар Баривчлах, цагдан хорих байрны дотоод журам 2013, Албадан ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн тогтоолыг гүйцэтгэхэд хяналт тавих журам 2013, Хуяглан хүргэх ажиллагааны журам 2014, Шүүгч, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журам 2014, Цагдан хорих байр, хорих ангийг нүүлгэн шилжүүлэх ажиллагааны үед хуяглан хүргэх ажиллагаа явуулах журам 2014, Гэрч хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам 2014, Гэрч хохирогчийг тусгай техник хэрэгслийн жагсаалт, хэрэгслээр хангах, хэрэглэх журам 2014, Гэрч хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам 2014, Гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам 2014, Биечилсэн хамгаалалтын журам 2014, Хорих ангийн харуул хамгаалалтын болон ялтанд хяналт тавих журам 2014, Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг байгууллагад байрлуулах журам 2014 онуудад тус тус баталсан.

32. Цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтцээр Гэмт хэрэгтэй тэмцэх газрын Мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн газрын Тусгай субъектын үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах хэлтсийг, Цагдаагийн ерөнхий газрын дотоод хяналт-аюулгүй байдлыг хангах газарт шилжүүлэн байгуулсан. “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”-ын код 224-д “Цагдаагийн алба хаагч түр саатуулагдсан этгээдтэй хэрцгий хүнлэг бусаар, басамжлан доромжилж харьцах, бие махбодь сэтгэл санааг шаналган зовоох аливаа санаатай үйлдэл хийх зэргээр эрүүдэн шүүж, зүй бусаар харьцахыг хориглоно” гэж заасныг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

33. Шүүхийн ерөнхий зөвлөлийн нэгдсэн мэдээгээр Эрүүгийн хуульд заасан эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт 2010–2014 онд 2010 онд 1 хэрэгт 1 хүн (Баян-Өлгий аймагт), 2013 онд 1 хэрэгт 1 хүн (Хөвсгөл аймагт), 1 хэрэгт 2 хүнд (Дорнод аймагт) тус тус Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйл ангиар ял оногдуулсан байна. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхтэй холбоотойгоор Прокурорын байгууллагаас шаардлага, албан даалгавар цагдаагийн байгууллагад ирүүлээгүй байна.

34. Мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн газрын уулзалт байцаалтын хэсгийг дүрс бичлэгээр бүрэн тоногосноор хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч, тагнуулын болон авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагч нар сэжигтэн, яллагдагчтай уулзах, байцаалт авахдаа байцаан шийтгэх ажиллагааны

оролцогч нарын аюулгүй байдал хангагдаж, хяналт хамгаалалт, нууцлал, дэг журмыг сахиулах ажиллагаа сайжран, эрүүдэн шүүх, хүнлэг бус харьцах тохиолдол 2014 онд гараагүй байна.

35. Олон улсын жишигт нийцсэн цагдан хорих 6 байрыг 2007–2011 онд ашиглалтад оруулж, 12 аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх албадын Цагдан хорих байрны их засварын ажлыг бүрэн хийж дуусгасанаар хорих байрны ахуй нөхцөл харьцангуй дээшилсэн. Хорих байгууллагын нөхцөлийг НҮБ–ын жишигт хүргэх чиглэлээр 2013 онд шинээр 5 стандарт батлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

36. Хууль сахиулах их сургуулийн Цагдаагийн сургуулийн сургалтын хөтөлбөрт Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн агуулга, үзэл санаа, Эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх арга замыг танин мэдэх асуудал зэрэг сэдвүүдийг тусгасан байна. Энэ хөтөлбөрийн дагуу 2008–2013 онд нийт 161 дамжааны 4909 сонсогч, сурагчид сургалтад хамрагдсан ирээдүйн хууль сахиулах байгууллагын боловсон хүчний мэдлэг, практик ажилд бодит үр нөлөө үзүүлнэ.

### **С. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр**

37. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх асуудлыг төрийн бодлогын баримт бичгүүд болох “Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого”, “Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”, “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”–үүдэд тусгайлан тусгаж, холбогдох олон улсын гэрээ, конвенциудад нэгдэн орсны зэрэгцээ “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”–ийг шинээр баталсан нь төрөөс энэ асуудлыг ихээхэн анхаарч, хүчин чармайлт гаргаж байгаагийн илрэл юм. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай үндэсний хөтөлбөрт нийгмийн ажил, сэтгэл зүй, эрх зүйн үйлчилгээг нэг цэгийн буюу хамтарсан багийн хэлбэрээр хүргэх тухай зорилт дэвшүүлж үүнтэй холбоотойгоор Монгол Улсын Засгийн газар 2009 онд “Осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх үндэсний хөтөлбөр” батлагдан хэрэгжүүлснээр гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд эмнэлэгт түшиглэсэн тусламж үйлчилгээ бий болгосон. Хүчирхийллийн хохирогчид үйлчилгээг үзүүлдэг байгууллага, мэргэжилтнүүд нь хоорондоо уялдаатай цогц үйлчилгээ үзүүлдэг байх шаардлагын үүднээс бүх шатны төрийн захиргаа болон үйлчилгээний байгууллагын шат, шатандаа хийж буй гэр бүл рүү чиглэсэн ажил үйлчилгээгээ нэгтгэж, нэг цэгийн үйлчилгээний зарчмаар хамтран ажиллах зохион байгуулалтын бүтцийг 2012 оноос “Хамтарсан баг”–ийн хэлбэрт оруулсан.

38. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээнээс үзвэл<sup>1</sup> 2010–2014 оны эхний 10 сарын байдлаар нийт 160380 гэмт хэрэг бүртгэгдсэнээс гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэгт 2828 гарсан байна. Сүүлийн дөрвөн жилд хүчирхийллийн хэргийн улмаас хохирогсдын тоо өсч байгаа бөгөөд 2010 онд 284, 2011 онд 420, 2012 онд 534, 2013 онд 514, 2014 оны эхний 10 сарын байдлаар 632 хүн гэмт хэргийн улмаас амь нас, бие махбодь эрүүл мэндээрээ хохирчээ. Энэ өсөлт нь ийм төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр сүүлийн жилүүдэд Засгийн газрын зүгээс

---

<sup>1</sup> ЦЕГ–ын Мэдээлэл судалгааны төвийн судалгаа

иргэд, олон нийтэд чиглэсэн сургалт сурталчилгаа, бүтэц зохион байгуулалтын олон талт арга хэмжээ авч хэрэгжүүлсэний дүнд иргэдийн ойлголт, эрх зүйн мэдлэг нэмэгдэж, цагдаагийн байгууллагаас тусламж үйлчилгээ хүссэн хандлага тоо нэмэгдсэнтэй холбоотой.

39. Гэр бүлийн хохирогчийг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх ажлыг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд явуулж байсан бол 2014 онд Засгийн газар анх удаа хохирогч хамгаалах байрыг байгууллаа. Уг хамгаалах байр нь 24 цагаар үйл ажиллагаа явуулдаг бөгөөд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдыг 1–30 хоногийн хугацаанд байрлуулан эмнэлгийн болон сэтгэл зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлж байгаа бөгөөд 2014 онд 140 гэр бүлийн 241 хохирогчийн байрлуулан туслалцаа үзүүлээд байна. Үүнд: насанд хүрсэн эрэгтэй–2, насанд хүрсэн эмэгтэй–109, эмэгтэй хүүхэд–91, эрэгтэй хүүхэд–130 байна.

40. Хамгаалах байрыг цагдаагийн байгууллагын бүтцэд бий болгосноор цагдаагийн байгууллага хохирогчийн эрсдэлийн түвшинг бууруулж, хэрэг маргааны асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэж, хохирогчид сэтгэл зүйн үйлчилгээ болон хууль эрх зүйн туслалцаа үзүүлж, улмаар нийгмийн ажилтантай хамтран нийгмийн халамж үйлчилгээнд хамруулах, холбон зуучлах ажлыг явуулах болсон нь хүчирхийллийн гэмт хэргийн хохирсон иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага тооцох ажиллагаа сайжирсан байна.

41. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд яаралтай тусламж цаг алдалгүй хүргэх зорилго бүхий 107 тусгай дугаарыг 2014 оноос 24 цагаар ажиллуулан дуудлага хүлээн авч байна. Энэ хугацаанд 478 иргэн үүний дотор хөдөө орон нутгаас 61, Улаанбаатар хотоос 368 иргэн хандан гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлэл, зөвлөгөө аваад байна. Мөн Хууль зүйн яамны харьяа Шүүх эмнэлгийн дэргэдэх Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөгсдөд үйлчлэх нэг цэгийн төв нь 2009 оны 12 дугаар сарын 15–ны өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулж байгаа ба тус төвөөр гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн 20–35 насны эмэгтэйчүүд 24–72 цагаар түр хамгаалах байранд байрлан эмнэлгийн тусламж үйлчилгээ авч байна. 2014 оны байдлаар тус төвөөр бэлгийн хүчирхийлэлд өртсөн 21, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 234 нийт 255 хохирогч эмнэлгийн туслалцаа аваад байна. Эдгээрээс хамгийн их буюу 95 хувь нь 25–38 насны хохирогчид байна.

42. Цагдаагийн байгууллага, алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт, ажлын байрны тодорхойлолтод нэмэлт, өөрчлөлт оруулж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр зохион байгуулсан ажлыг дүгнэдэг болсон.

43. Далд үйлдэгддэг энэ гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогчдод цаг алдалгүй туслалцаа үзүүлэхэд энэ чиглэлээр ажилладаг төрийн байгууллагын алба хаагчдын мэдлэг ур чадвар өндөр байх зайлшгүй шаардлагатай тулгарч байна. Уг ажлын хүрээнд Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ–тай хамтран 2013–2014 онд нийслэлийн 9 дүүргийн цагдаагийн хэсгийн байцаагч, нийгмийн ажилтнууд нийт 250 гаруй алба хаагчдыг Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх чадавхийг бэхжүүлэх нь сэдэвт сургалтад хамрууллаа. Уг сургалтыг орон нутагт явуулж эхлээд байгаа ба одоогийн байдлаар 600 гаруй цагдаагийн хэсгийн байцаагч, нийгмийн

ажилтан хамрагдан гэр бүлийн хүчирхийллийн онцлог, суурь шалтгааныг олж мэдэхээс гадна гэр бүлийн хохирогчдод хэрхэн багаар туслалцаа үзүүлэх, хохирогч хамгаалах тухай хууль тогтоомж, хохирогчийн аюулгүй байдал, тэдний эрх, онцлог хэрэгцээнд тулгуурлан үйлчилгээг хэрхэн багаар өндөр түвшинд хүргэх талаар суралцаж байна.

44. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт явуулах журам, сургалтын хөтөлбөрийг Хууль зүйн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд хамтран баталсан. Хууль зүйн яамны санхүүжилтээр Цагдаагийн ерөнхий газрын харьяа Олон нийт цагдаагийн хамтын ажиллагааны төв “Эрчүүд–эрүүл гэр бүл” ТББ–тай хамтран гэр бүл хүчирхийлэл үйлдэгчдэд албадан сургалтыг Баривчлах төвд 2014 оны 10 сараас эхлэн явуулж байна. Энэ сургалтад шүүгчийн шийтгэврээр баривчлагдан ирсэн 343 хүн хамрагдаад байна.

45. Нийслэлийн цагдаагийн газрын бүтцэд ажиллах Хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нэгжид эмэгтэй хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч ажиллуулах болсон.

46. Гэр бүлийн хүчирхийллийн нэг шалтгаан нь гэр бүлийн боловсрол дутмагаас болж байгаа учир гэр бүлийн боловсрол олгох албан болон албан бус сургалтын 3–4 төрлийн модуль боловсруулан сургалт явуулж байна.

#### **D. Хүн худалдаалахтай тэмцэх**

47. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий “Дэд зөвлөл”–ийг Хууль зүйн яаманд байгуулсан. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулинд Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг батлуулахаар заасны дагуу хөтөлбөрийн төслийг боловсруулаад байна. Энэхүү хөтөлбөрийн гол зорилго нь хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, цаашид энэ төрлийн гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, сургалт сурталчилгааны оновчтой аргыг хэрэглэн зорилтот бүлгүүдийг хамруулах явдал юм. Мөн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсөлд уг гэмт хэргийн төрлүүд болох бэлгийн мөлжлөг, хөдөлмөрийн мөлжлөг, зуучлалын буюу захиалгат гэрлэлт, хүүхэд үрчлэлт, эд эрхтэний наймаа зэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, хохирогчийг хамгаалах асуудлыг хамруулсан.

48. Хүн худалдаалах гэмт хэргийн мэдээллийн нэгдсэн сан байгуулах ажлыг хийж байна. Уг сан нь гэмт хэрэг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэглэгдэх төрийн байгууллагууд хоорондын мэдээллийн сан байх юм.

49. Засгийн газар Хүн худалдаалах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөрийг 2014 он хүртэл 3 үе шаттайгаар 9 жилийн хугацаатай хэрэгжүүлсэн бөгөөд цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

50. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг гэмт хэрэгт татахгүй байх, хохирогчдод нөхөн төлбөр олгох, нийгэмшүүлэх хандлагыг хэрэгжүүлэх чиглэлээр хилийн чанадад хүн худалдаалах гэмт хэргийн улмаас эрх ашиг нь зөрчигдсөн Монгол Улсын иргэдийг эх оронд нь аюулгүй авч ирэх ажиллагааг Гадаад хэргийн яамны Консулын

газар, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж байна. Тухайлбал 2014 онд хүн худалдаалах болон бусад гэмт хэргийн хохирогч болсон 36 иргэнээ буцаан авч ирсэн байна.

51. Хүний наймааны хүлээн авагч газруудын нэг БНХАУ-ын Макаогийн засаг захиргааны онцгой бүсийн засгийн газартай Хүн худалдаалахтай тэмцэх асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг 2010 онд, БНХАУ-тай Гэмт хэрэгтэй тэмцэх талаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг 2011 онд тус тус байгуулан, хэрэгжүүлж байна. Хилийн чанадад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон иргэнд туслалцаа үзүүлэх, түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эх оронд нь буцаан авч ирэхэд шаардагдах зардал гаргах журмыг 2013 онд батлан мөрдөж байна.

52. “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” Монгол Улсын стандартыг баталсан бөгөөд энэхүү стандартын зорилго нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх олон нийтэд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, уг үйлчилгээний орчныг тодорхойлох, улмаар тус үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд оршино.

53. 2013 онд хүн худалдаалах 12 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хүүхэд хохирогчоор тогтоогдсон 1 хэрэг байна. 2014 оны байдлаар хүн худалдаалах гэмт хэрэг 15 гарснаас 10 хэрэгт яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлж, 5 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явагдаж байна. 2010–2014 онд Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хохирсон нийт 17 хохирогчийг хохирогч хамгаалах байранд байрлуулан, эрх зүйн болон эрүүл мэндийн туслалцаа үзүүлж нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулсан.

#### **Е. Гэрч, хохирогчийг хамгаалах чиглэлээр**

54. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу “Гадаад төрхийг өөрчлөх аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ авах тухай”, “Гэрч, хохирогчийн баримт бичгийг солих журам”, “Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам”, “Нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах, хэрэглэх журам”, “Гэрч, хохирогчдод эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам”-ыг Хууль зүйн сайд батлан, мөрдүүлж байна.

55. Гэрч, хохирогчийг өөрийнх нь зөвшөөрснөөр, насанд хүрээгүй гэрч, хохирогчийг түүний эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, эсхүл хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын зөвшөөрснөөр аюулгүй байдал хангагдсан газарт түр байрлуулна. Мөн гэрч, хохирогчийг аюулгүй газарт байрлуулахдаа эрсдлийн ямар түвшинд байгааг тогтоон хамгаалалтын арга хэмжээ авах ба хамгаалалтанд байх хугацаанд сэтгэл зүйн болон хууль зүйн туслалцааг Тахарын албаны хамгаалалтын тусгай нэгжийн дэргэдэх мэргэжлийн баг үзүүлнэ. “Гэрч, хохирогчдод эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам”-д хамгаалуулагчид эрүүл мэндийн туслалцаа үйлчилгээг бүх шатны эрүүл мэндийн байгууллага өмчийн хэлбэрээс үл хамааран үзүүлэхээр тусгагдсан бөгөөд хэрэв хамгаалуулагч эмнэлэгт хэвтэж, эмчлүүлж эмнэлгийн тусламж авах бол түүний аюулгүй байдлыг хамгаалалтад авсан байгууллага хариуцахаар заасан.

56. “Нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах, хэрэглэх журам”-д гэрч хохирогчийн аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээний үед нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангахдаа гэрээ байгуулан тэдгээрийг хэрхэн ашиглах талаар заавал зөвлөгөө өгөх, ямар хугацаанд хэрэглэх, хэрэглэх хугацааг хэн тогтоох, мөн тусгай техник хэрэгслийн жагсаалтыг уг журмаар баталсан.

57. Гэрч, хохирогчийг хамгаалах чиглэлээр цагдаагийн байгууллагын зүгээс “Хүн худалдаалахтай тэмцэх тухай” бие даасан хууль батлагдсантай холбогдуулан гэрч болон хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг энэхүү хуулийн зарчимд бэхжүүлэн оруулсан, түүнчлэн “Цагдаагийн албаны тухай” хууль /2013 он/, “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”-ын код-244 /Гэрч, хохирогчийг хамгаалах/, 228 /Эрэн сурвалжлах ажил/, 305 /Гэмт бүлэглэлийн талаар мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах/ болон Гэрч, хохирогчтой харилцахад баримтлах журам /2014 он/-д гэмт хэргийн улмаас хохирсон гэрч, хохирогчийг хамгаалах талаарх цагдаагийн байгууллагын хэм хэмжээг тусгаж өгсөн нь гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн эрх зүйн орчин сайжрах алхам болсон.

58. Гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, сэтгэл зүйн болон хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх зорилгоор дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхтэй хамтран тус шүүхийн байранд Гэр хохирогчид туслалцаа үзүүлэх өрөөг тохижуулж 2014 онд ажиллуулж эхлэв. Тус өрөөнд гэмт хэрэг хянан шийдвэрлэх явцад гэрч, хохирогчийг сэжигтэн, яллагдагчтай уулзаж сэтгэлийн дарамтад орохоос урьдчилан сэргийлэх, шүүх хуралдаанд биечлэн оролцохгүй, өрөөнөөсөө шүүх хуралдааны явцыг ажиглах, мэдүүлэг өгөх боломжоор хангалаа.

#### **Ү. Авлигын эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээ**

59. Төрийн үйл ажиллагааны ил тод байдал болон иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах зорилгоор Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг 2011 онд батлан мөрдөж байгаа нь авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүнд эерэгээр нөлөөлөх боломжийг бүрдүүлсэн. Төрийн албаны ил тод байдлыг хангах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг 2012 онд баталсан.

60. Энэ хуулийн дагуу төрийн албан хаагч, албан тушаалтан ажилд томилогдохоос өмнө хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг гаргах үүрэгтэй бөгөөд хуулийн хэрэгжилт маш сайн байна. Авлигатай хийж буй тэмцэл, хуулийн хэрэгжилтийг олон нийтэд ил тод байлгах үүднээс тодорхой албан тушаалтнуудын орлогын мэдүүлгийн бүртгэлийн талаар цахим хуудас болон бусад олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тогтмол мэдээлж байна.

61. Авлигын эсрэг хуулинд 2012 онд нэмэлт, өөрчлөлт орж мэдээлэх үүргийг хэрэгжүүлэхэд төр, байгууллага, хувь хүний нууцын тухай хуулиар тогтоосон хязгаарлалт хамаарахгүй байхаар зохицуулсан нь авлигын хэрэг илрүүлэлтэд эерэгээр нөлөөлж байна.

62. Авлигатай тэмцэх газрын бие даасан байдлыг хангах зорилгоор Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албыг Авлигатай тэмцэх газарт нэгтгэснээр тагнуул, цагдаагийн байгууллагын ажилтан, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчид холбогдох албан тушаалын гэмт хэрэгт мөрдөн байцаах ажиллагаа явуулах боломжтой болсон.

63. УИХ Шилэн дансны тухай хуулийг 2014 онд батласан. Энэ хуулийн дагуу төрийн болон төрийн өмчийн оролцоотой байгууллагууд төрийн нууцад хамаарахаас бусад төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайланг байгууллагын нууцад хамааруулахыг хориглож, өөрсдийн цахим хуудсаар тогтмол мэдээлж байх үүрэг хүлээсэн.

64. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах, олон улсын жишигт хүрсэн зохицуулалт бий болгох зорилгоор Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг 2013 онд батлан мөрдөж байна.

### **Г. Эмэгтэйчүүдийн эрхийг хангах чиглэлээр**

65. Жендэрийн тэгш байдлыг хангах тухай тухайлсан хууль батлах, эмэгтэйчүүдийг хүйсээр ялгаварлан гадуурхах явдлыг бүхий л салбарт хориглох, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх тухай зөвлөмжийг олон орон өгсөний дагуу “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”-ийг 2011 онд баталсан.

66. 2012 онд шинэчлэн баталсан “Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль”-д нам, эвслээс УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн 20-иос доошгүй хувь нь эмэгтэйчүүд байхаар тусгасан. УИХ-ын 2012 оны сонгуульд нэр дэвшигчдийн 32 хувь нь эмэгтэйчүүд байсан бөгөөд сонгогдсон нийт 76 гишүүний 14.47 хувь нь буюу 11 эмэгтэй гишүүн байгаа нь өмнөх Парламент дахь эмэгтэй гишүүдийн тооноос 4 дахин их байна.

67. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд яам, агентлаг болон орон нутгийн удирдлагын байгууллагад эмэгтэйчүүдийн төлөөлөл бүх түвшинд 15–40 хүртэлх хувиас доошгүй байхаар заасан. Төрийн захиргааны албанд нийт 17.9 мянган албан хаагч ажиллаж буйн 57.4 хувь нь эмэгтэй байгаагаас 27.6 хувь нь ахлах албан тушаал хашиж байна.

68. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль батлагдснаас хойш жендэрийн ялгаварлан гадуурхалтай холбоотой ажлын байрны бэлгийн дарамт, гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар ХЭҮК 2011 онд 5, 2012 онд 9, 2013 онд 16, 2014 оны 6 сарын байдлаар 9 гомдол, нийт 39 гомдол хүлээн авч хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

69. Эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор зарим аймагт “Эх, нярайн эрүүл мэндийн сан” байгуулж, сангийн хөрөнгөөр нэн ядуу эх, нярайн эмчилгээг санхүүжүүлж байна. Алслагдсан нутгийн малчин иргэдэд эмнэлгийн тусламж үзүүлэх нүүдлийн амбулатори, мэргэжлийн эмч нарын багийг сумдад ажиллуулснаар яаралтай дуудлага буурсан.

70. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу эхчүүдийн нийгмийн хамгааллыг бэхжүүлэх зорилгоор нийгмийн даатгал, халамжийн сангаас жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгодог. Хүний хөгжил сангаас Хүүхдийн мөнгийг Монгол

Улсын 0–18 хүртэлх насны хүүхэд бүрт олгодог.

71. Эхийн эндэгдлийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ тодорхой үр дүнд хүрч, эхийн эндэгдэл сүүлийн жилүүдэд тогтмол буурч байна. Тухайлбал эхийн эндэгдлийн түвшин тоон үзүүлэлтээр 2012 онд 51.5, 2013 онд 42.6, 2014 оны эхний 11 сарын байдлаар 33.2 болж буурсан. Малчин эмэгтэйчүүдийн эндэгдлийн нийт эндэгдэлд эзлэх хувь нь 2004 онд 49 хувь байсан бол 2010 онд 37, 2012 онд 13 хувь болж буурсан.

72. Шинээр боловсруулсан Эрүүгийн хуулийн төсөлд ажлын байран дахь бэлгийн дарамтыг гэмт хэрэг гэж тооцохоор тусгасан.

73. Монгол Улсад охид, хөвгүүд, эмэгтэй, эрэгтэйчүүд нь бага боловсрол, бүрэн дунд, дээд, тусгай мэргэжлийн болон шинжлэх ухаан, технологийн гэх зэргээр бүхий л салбарт боловсролыг тэгш хүртэх боломжийг бүрдүүлсэн. Монгол Улсын Засгийн газар Боловсрол шинжлэх ухааны яамны дэргэд насан туршийн боловсролын төвийг байгуулан ажиллаж байна. Хуульд зааснаар охид, хөвгүүд, эмэгтэй, эрэгтэйчүүд боловсрол тэгш хүртэх боломжийг хангасан бодлогын хэрэгжилт, чанар үйлчилгээ, үйл ажиллагаанд нь мэргэжлийн хяналтын боловсролын байцаагчид хяналт тавьж ажилладаг.

#### **Н. Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр**

74. Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл хүүхэд бүрийг үл хайхрах, хүчирхийлэх, хүүхдийн хөдөлмөрийг мөлжих явдлаас сэргийлэх, хамгаалах тогтолцоог хөгжүүлэх зорилт бүхий Хүүхэд хамгааллыг бэхжүүлэх стратеги (2010–2015)–ийн бодлогын баримт бичгийг 2010 онд батлан, түүнийг хэрэгжүүлэхээр төлөвлөгөө гарган ажиллаж байна. Стратегийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2012 оноос эхлэн жилд дунджаар 400–500 сая төгрөгийг Засгийн газраас олгож байна.

75. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөрийг 2011 онд, Хүүхдийн хөгжлийн шаталсан хөтөлбөрийг 2013 онд тус тус батлан хэрэгжүүлж байна.

76. Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй нийт 428 хуулийн 60 орчимд нь хүүхэд, хүүхдийн эрхийн холбогдолтой 350 гаруй заалт байдаг. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн үзэл санаанд нийцүүлэн хүүхдийн талаарх үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох зорилгоор Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн төслүүдийг эцэслэн боловсруулсан бөгөөд одоо батлуулахаар ажиллаж байна. Эдгээр хуулийн төсөлд хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг бууруулах зохицуулалт, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн<sup>2</sup> найруулгын төсөлд 15 насанд хүрээгүй хүнээр хөдөлмөр эрхлүүлэхийг хориглох зохицуулалт, Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хүүхэд үрчлэлийн эрх зүйн зохицуулалтыг холбогдох олон улсын гэрээнд нийцүүлэн тусгасан болно.

<sup>2</sup> Хуулийн төслийг анхдагч болон шинэчилсэн найруулга гэж ангилдаг. Нийгмийн тодорхой харилцааг анх удаа хуульчлан зохицуулах бол тухайн хуулийн төслийг анхдагч, харин харилцааг зохицуулж байсан хуулийг өөрчлөх, ингэхдээ хуулийн зохицуулалтын 50 болон түүнээс дээш хувьд нь өөрчлөлт оруулах тохиолдолд тухайн хуулийн төслийг шинэчилсэн найруулга гэж ойлгодог.



77. Монгол Улс Хүүхдийн эрхийн конвенцийн Мэдээлэл хүргүүлэх журмын тухай нэмэлт протоколыг соёрхон батлах чиглэлээр ажиллаж байна. Түүнчлэн ХҮЭК Хүүхдээс гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, хуваарилах, шийдвэрлэх журмыг 2012 онд баталсан. Хүүхдийн эрхийн асуудлаар хүүхэд болон насанд хүрэгчдээс ХЭҮК-т гаргасан нийт өргөдөл, гомдлоос 2010 онд 6, 2011 онд 10, 2012 онд 10, 2013 онд 12-ыг нь бүрэн шийдвэрлэсэн байна.

78. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, бие махбодийн далд шийтгэл тодорхой хэмжээнд байгаа бөгөөд ийм нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, бүртгэх, хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн системд оруулах зорилгоор хүүхдийн тусламжийн утасны үйлчилгээ үзүүлж байна. Хүүхдийн тусламжийн утас 108 нь 24 цагийн /үнэ төлбөргүй/ үйлчилгээтэй бөгөөд хүүхдийн эрхийн зөрчлийн тухай иргэд, байгууллагын мэдээллийг нарийвчлан бүртгэж, эрсдлийн үнэлгээ хийж байна. Тус утас нь 2013 оны жилийн эцсийн байдлаар 42946 зорилтод дуудлага хүлээн авч, үйлчилсэн байна. Хүүхдийн тусламжийн утас нь Хүүхдийн байгууллагын чиг үүргийн дагуу кейст тулгуурлан үзүүлэх үйлчилгээний тогтолцоог бий болгох үндсэн үйл ажиллагаа юм. Уг төслийн санхүүгийн дэмжлэгийг 2014 оны 6 дугаар сарын 1-нээс эхлэн 3 жилийн хугацаанд Мобиком, Дэлхийн зөн ОУБ хамтран үзүүлж байна.

79. Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага MNS 6264:2011 стандартыг 2012 оноос мөрдөн хэрэгжүүлснээр уралдаанч хүүхдийн эрхийг хамгаалах тал дээр ахиц гарсан боловч цаашид анхаарах асуудал байсаар байна.

80. Засгийн газраас 2011 онд баталсан Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах 2012–2016 оны үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын дэмжлэгтэй боловсруулсан бөгөөд хөтөлбөрт хүүхдийн хөдөлмөрийг зохицуулах хууль тогтоомжийг нэгдэн орсон олон улсын гэрээний зарчимд нийцүүлэх, энэ чиглэлийн хууль сахиулах байгууллагын чадавхийг сайжруулах, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт өртсөн хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах үндсэн зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. 2013 оны байдлаар 93968 хүүхэд хөдөлмөр эрхэлж байгаагийн 10398 хүүхэд хүнд хэлбэрийн хөдөлмөр эрхэлж байна.

81. Мэргэшсэн хөдөлмөрийн байцаагчдыг нэмэгдүүлэх замаар хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн хяналтыг дээшлүүлэх зорилгоор 2009 онд Хүүхдийн хөдөлмөрт хийх хяналт шалгалтын аргачлалыг боловсруулж улсын хэмжээнд хэрэгжүүлэхийг даалгасан. Энэ аргачлалын дагуу хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчид аж ахуйн нэгж байгууллагад 2012 онд хийсэн шалгалтаар 1012 хүүхэд хөдөлмөр эрхэлж байгааг тогтоож, хууль журмын дагуу холбогдох арга хэмжээ авсан.

82. Хөдөлмөр эрхэлж буй хүүхдэд тусгайлан чиглэсэн нийгмийн үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал байна. Хөдөлмөр эрхэлж буй хүүхдэд өдрийн үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төв 2010 оноос нийслэлд ажиллаж эхэлсэн ч төсөв, санхүүгийн хомсдолоос шалтгаалан өнөөгийн байдлаар цөөн хүүхдэд хүрч үйлчилж байна.

83. Хөдөлмөрийн төв бирж “Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр”–

ийн хүрээнд 2013–2014 онд 16–18 насны 81 хүүхдийг тэдгээрийн хүсэлтийн үндсэн дээр мэргэжлийн сургалтад хамруулсан. Түүнчлэн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн газар 2012–2013 онд сайн дураараа хөдөлмөр эрхлэгч 5–17 насны 180 хүүхдийг нийгэмшүүлэх сургалтад хамруулсан байна.

### **I. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр**

84. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн төслийг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамнаас боловсруулж байгаа бөгөөд тайлангийн хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг дэмжих, оролцоог хангах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, сурч боловсрох, хүчирхийлэл, ялгаварлалаас ангид байх болон бусад эрхийг баталгаажуулах зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийг 2013–2016 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөнд аймаг, дүүрэг, холбогдох газрууд нарийвчилсан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх чиглэлээр ажиллаж, хэрэгжилтийн тайланг холбогдох яамд, агентлаг, аймаг, дүүргээс нэгтгэн авч Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхаар заасан нь хяналтын механизмыг бүрдүүлсэн бөгөөд энэ ажил бүрэн хэрэгжсэн.

85. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийг шинэчлэн найруулах ажлын хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”-ийн төслийг шинээр боловсруулан төр, төрийн бус байгууллага, иргэд, олон нийтээс санал авах уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хуулийн үзэл баримтлалын төслийг 2014 оны 10 дугаар сарын 18–ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн бөгөөд одоо хуулийн төслийг эцэслэн боловсруулж байна.

86. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссыг 2013 онд байгуулсан. Тус комисс 4–16 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засалтын анхан шатны бүртгэлийн маягт, 0–3 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх үнэлгээний хуудас боловсруулж, “0–3 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлт” арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулав. Монгол Улсын 21 аймаг 9 дүүргийн тайлангийн нэгтгэлээр улсын хэмжээнд 0–3 насны нийт 134579 хүүхэд үзлэгт хамрагдсан байна. Хөдөө орон нутгийн 21 аймгаас 99208 хүүхэд, нийслэлийн 9 дүүргээс 35371 хүүхэд хамрагдсан. Нийт үзлэгт хамрагдсан 0–3 насны хүүхдийн 73,7% нь аймгуудаас, 26,3% нь нийслэлийн дүүргүүдээс хамрагдсан. Хэвийн хөгжилтэй 132614 буюу 98,5%, хөгжлийн хоцрогдолтой хүүхэд 1965 буюу 1,5 ийг тус тус эзэлж байна.

87. Тэгш дүүрэн хөтөлбөрийн хүрээнд Хөвсгөл, Орхон, Архангай, Өмнөговь аймаг, нийслэлийн Сүхбаатар, Баянзүрх, Багахангай дүүрэгт нийт 25,5 сая төгрөгийн өртөг бүхий сэргээн засах кабинет, ортопедийн цех байгуулав.

88. Эрүүл мэнд, спортын яамнаас Хүүхдийн осол гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөр, Нярайн тандалт, шинжилгээний хөтөлбөр (2014–2020)-ийг 2013 онд баталж, тархины саатай хүүхдүүдийн эцэг эхчүүдэд зориулсан сургалтыг 4 аймаг, нийслэлийн 3 дүүрэгт зохион байгуулав.

89. Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог бууруулах зорилгоор ургийн хөгжлийн гажиг, удамшлын эмгэгийг эрт оношлох, анагаах ухааны удам зүй, пренатологийн оношилгооны лабораторийг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд байгууллаа.

90. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах хөтөлбөрийн 2 дахь шатны төслийг хэрэгжүүлж байна. Тусгай хэрэгцээт боловсролын багш нарыг Монгол Улсын Боловсролын их сургуульд 1 жилийн мэргэшил дээшлүүлэх сургалтад хамруулж байна. Энэ хүрээнд улсын төсвөөс санхүүжүүлж хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан Сургалт, оношилгооны лабораторийг тус сургуульд байгуулсан. 2013 оны Хөдөлмөрийн яамны тайлангаар Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд суралцдаг нийт 42798 суралцагч байдгаас хөгжлийн бэрхшээлтэй 513 хүүхэд суралцаж байна.

91. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суралцах орчныг сайжруулах ажлын хүрээнд уншлагын танхим, багш, суралцагчийн хөгжлийн танхим, эмчилгээний биеийн тамирын өрөө бүхий 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын өргөтгөлийг барьж хүлээлгэн өгснөөр анги танхимд суралцах, сургалтын үйл ажиллагаа явуулах боломж нөхцлийг бүрдүүлсэн. Мөн 2013–2014 оны хичээлийн жилд тусгай сургуулийн зарим сурах бичгийг бүтээж, тусгай сургалттай 5 сургуульд суралцаж буй сурагчдын статистик мэдээнд үндэслэн хэвлэн, ашиглаж байна.

92. Засгийн газраас 2012 онд баталсан тусгай сургалтын байгууллагын зардал тооцох журамд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагад санхүүжилт олгоходоо нэг сурагчийн хувьсах зардлын нормативыг 3 дахин нэмэгдүүлж тооцохоор шийдвэрлэсэн. Ерөнхий боловсролын сургуулийн багшийн мэргэжлийг дээшлүүлэх, давтан сургах хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй, сурган сэтгэл судлалын агуулгыг тусгах, тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр сургалт явуулах зэрэг тодорхой үр дүнтэй ажлуудыг хэрэгжүүлж байна.

93. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль, цэцэрлэгт хамрагдалтын тоог нэмэгдүүлэх чиглэлээр Тусгай хэрэгцээт боловсролын багш нарыг дотооддоо бэлтгэн Монгол Улсын Боловсролын Их сургуулийн, сургуулийн өмнөх боловсролын сургуульд тусгай хэрэгцээт боловсролын багшийн мэргэжлийн 1 жилийн сургалттай ангийг нээн хичээллүүлж байна. Төрийн байгууллагын хүсэлт, олон улсын байгууллагын дэмжлэгээр харааны бэрхшээлтэй хүүхдийн 116 дугаар сургуульд хараагүй болон сул хараатай хүүхдүүдэд зориулсан брайль принтер, таяг, линз, брайль бичгийн цаас, томруулдаг шил зэрэг 46 сая төгрөгийн өртөг бүхий сургалтын тоног төхөөрөмж, тусгай боловсролын сургуулиудад зориулалтын өргөгч лифт бүхий автобус, микро автобус нийлүүлэв.

94. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах хөгжлийн бэрхшээлтэй иргэний бизнес төслийн шалгаруулалтад улсын хэмжээнд нийт 2159 төсөлд 2 тэрбум 668 сая төгрөгийн санхүүжилт олгож, 1660 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажлын байртай болсон байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн дунд хязгаарлагдмал тендер зарлаж 33 төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид 759,4 сая төгрөгийн

санхүүгийн дэмжлэгийг олгож, 114 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байнгын ажлын байртай болсон байна. Үүнээс гадна хөгжлийн бэрхшээлтэй 91 иргэнийг байнгын ажлын шинэ байраар хангасан аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагад санхүүгийн дэмжлэг үзүүлж байна.

95. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих ангиудад 2013 онд 162 хөгжлийн бэрхшээлтэй ялтан, 2014 онд 157 хөгжлийн бэрхшээлтэй ялтан тус тус ял эдэлж байна. Үүнээс 2013 онд 99, 2014 онд 77 хөгжлийн бэрхшээлтэй ялтнуудыг өөрсдийнх нь хүсэлтийг харгалзан өөрт нь тохирсон ажлын байраар хангаж, номын санч, зээгт наамал, хэрээсэн хатгамал зэрэг хорих ангийн дотоодын үйлдвэрлэлд ажиллуулан шагналын хоног, цалин олгох асуудлыг шат дараалалтайгаар шийдвэрлэж, гэм хорын төлбөрийг зохих хувиар барагдуулаад байна.

96. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай болон Нийгмийн халамжийн тухай хуулиар зорилтот бүлэгт чиглэсэн 68 төрлийн тусламж үйлчилгээ, зохих хөнгөлөлт олгогдож байна. 2013 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэд хувиараа болон нөхөрлөл хоршооны хэлбэрээр аж ахуй эрхлэхэд 1 сая хүртэл төгрөгөөр тооцож, 10 сая хүртэл төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгоход 1 тэрбум төгрөг төсөвлөсөн /аймагт 10–35, дүүрэгт 60–80 сая төг/. Үүнээс 883 төсөл шалгаруулж, 986,0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосноор нийт 1439 ажлын байр, үүнээс хөгжлийн бэрхшээлтэй иргэний 996 байнгын ажлын байр бий болсон.

97. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд сонгох эрхээ эдлэх нөхцлийг бүрдүүлэх үүднээс анх удаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны сонгуулиар 3–4 санал авах байранд тэргэнцэртэй сонгогч ирж саналаа өгөх зориулалтын замыг байршуулав. Мөн харааны бэрхшээлтэй иргэдэд зориулан санал авах бүхээгт томруулдаг шил, ойрын харааны нүдний шил, брайль үсэг бүхий хавтсыг байрлуулснаар анх удаа хараагүй иргэд итгэмжилсэн хүний туслалцаагүйгээр бие даан санал өгсөн.

#### **Ж. ЛГБТ хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлээр**

98. Монгол Улс бүх төрлийн ялгаварлан гадуурхах үйлдлийг хуулиар хориглох, түүнтэй тэмцэх зорилгоор Арьс үндсээр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенцийн 14 дүгээр зүйлийг хүлээж авах боломжийг судалж байгаагаас гадна шинээр боловсруулж буй Эрүүгийн хуулийн төсөлд “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, төрх байдал, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар нь ялгаварлан гадуурхаж, эрх, эрх чөлөөг нь хязгаарласан, тодорхой үйлдэл, эс үйлдэхүй шаардсан, заналхийлсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэж оруулсан.

99. ЛГБТ хүмүүсийн эсрэг гардаг ялгаварлан гадуурхал, хүний эрхийн зөрчил уламжлалт чиг хандлагаа даган тодорхой хэмжээнд оршин тогтносоор байна. Бэлгийн чиг баримжаа буюу хүйсийн чиг баримжаанаас нь хамаарч ялгаварлан гадуурхахтай тэмцэх, хүний эрхийн боловсрол, мэдээллийг олон нийтэд түгээх, олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх зорилгоор 2012 онд хийсэн Монгол Улс дахь ЛГБТ хүмүүсийн эрхийн хэрэгжилтийн судалгааны дүнг ХЭҮК-ийн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний

байдлын талаарх 12 дахь илтгэлд тусгаж, УИХ-ын Хууль зүйн байнгын хороогоор хэлэлцүүлсэн.

100. “ЛГБТ хүмүүсийн эрхийн талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх нь” төслийн хүрээнд ЛГБТ хүмүүсийн талаарх нийгэмд үүссэн сөрөг дүр төрх болон дургүйцлийг бууруулах, хүмүүсийн хандлага, сэтгэлгээний соёлыг дээшлүүлэх, тэдний эрхээ эдлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилго бүхий ТББ-ын хэрэгжүүлсэн төслийн хүрээнд ТВ шторк болон баримтат нэвтрүүлгийг үндэсний хэд хэдэн телевизээр дамжуулан олон нийтэд хүргэсэн нь зохих үр дүнгээ өгсөн.

#### **К. ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр**

101. Эрүүл мэндийн тухай хуулийг (шинэчилсэн найруулга) 2011 онд, Хүний дархлал, хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийг (шинэчилсэн найруулга) 2012 онд тус тус баталсан. Эдгээр хуульд хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ялгаварлан гадуурхахгүйгээр тэгш, хүртээмжтэй үзүүлэх, хүний эрх, эрх чөлөөг ХДХВ-ын халдвар авсан буюу ДОХ-той гэсэн үндэслэлээр хязгаарлахыг хориглох, уг хүнийг гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг хориглох тухай зохицуулалтыг шинээр буй болгосон.

102. Бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ), ХДХВ/ДОХ-оос сэргийлэх үндэсний стратеги төлөвлөгөө (2010–2015)-нд 2013 онд дунд хугацааны үнэлгээ хийж, Эрүүл мэнд, спортын яам, Халдварт өвчин судлалын үндэсний төвтэй хамтран төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааг зохицуулах болсноор БЗДХ, ХДХВ/ДОХ-оос сэргийлэх нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх механизм бүрдсэн.

103. Монгол Улс ХДХВ-ын халдварын бага тархалттай улсын тоонд ордог бөгөөд цус, цусан бүтээгдэхүүн, эхээс урагт халдвар дамжсан тохиолдол одоогийн байдлаар бүртгэгдээгүй байна. 2014 оны байдлаар Монгол Улсад бүртгэгдсэн ХДХВ/ДОХ-ын халдвартай эмчилгээнд орох шаардлагатай нийт 126 хүнээс 100% буюу бүгд ретровирусын эсрэг эмчилгээнд хамрагдаж байгаа бөгөөд 2013 оноос тэдний эмчилгээний эмийн зардлыг Монгол Улсын Засгийн газраас гаргаж байгаа. Энэ нь ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж сайжирч байгааг илэрхийлж байна.

104. Монгол Улс БЗДХ, ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх үүднээс улсын хэмжээнд ХДХВ-ийн халдвар илрүүлэх сайн дурын зөвлөгөө, шинжилгээний төвүүдийг ажиллуулж иргэдэд үйлчилгээг илүү ойртуулж байна. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Тандалт судалгааны алба нь улсын хэмжээнд сургалтыг зохион байгуулж байна.

#### **Л. Боловсролын эрхийг хангах чиглэлээр**

105. Монгол Улс мэдээлэл холбооны технологид суурилсан, нээлттэй, насан туршийн, тасралтгүй, чанартай боловсролыг эзэмших боломжийг бий болгох нээлттэй боловсролын “Нэг Монгол” үндэсний хөтөлбөрийг 2014 онд батлан хэрэгжүүлж эхлээд байна.

106. Сургууль завсардсан болон тодорхой шалтгааны улмаас сургуулийн гадна буй иргэдэд бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох, иргэдэд бичиг үсгийн

болон амьдрах ухааны боловсрол олгох үйл ажиллагааг Боловсролын тухай хууль, Албан бус боловсролын сургалтын талаар баримтлах бодлого (2010), Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр сургалт явуулах журам (2007) зэрэг хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлж байна.

107. Боловсрол нөхөн олгох дүйцсэн хөтөлбөрт 2011–2012 оны хичээлийн жилд хамрагдан тэнцсэн 12025 суралцагч, 2012–2013 оны хичээлийн жилд хамрагдан тэнцсэн 11810 суралцагчдад суурь боловсролын гэрчилгээ, бүрэн дунд боловсролын үнэмлэх олгосон. Мөн бичиг, үсгийн анхан болон дунд шатны сургалтад 9000 хүнийг хамруулсны дотор сүм, хийдэд шавилан суудаг 120, алслагдсан баг, хороонд амьдарч буй 78 хүүхдийг хамрууллаа.

108. 2013–2014 оны хичээлийн жилд насан туршийн суурь боловсрол нөхөн эзэмшүүлэх дүйцсэн хөтөлбөрт 1573 суралцагч, бүрэн дунд боловсролын түвшинд эчнээ, оройн ангид 849, насан туршийн боловсролын бүрэн дунд боловсрол олгох дүйцсэн хөтөлбөрт 1391 суралцагч хамрагдаж төгссөн.

109. Ерөнхий боловсролын сургуулийн түүх, нийгэм судлалын хичээлийн сургалтын хөтөлбөрт хүний эрх, эрх чөлөө, ардчиллын төлөө тэмцэл гэсэн бүлэг нэмж оруулсан.

110. Үндэсний боловсролын болон эрүүл мэндийн тогтолцоог хөгжүүлэхэд хувийн хэвшлийн оролцоог түлхүү нэмэгдүүлэх зорилгоор мэргэжлийн зэргийн шалгалтыг зохион байгуулах эрхийг ТББ–д олгож, зохион байгуулах нийгэмлэг, холбоодыг тусгай шалгуурын дагуу сонгон ажиллуулж байна.

111. 2013–2014 оны хичээлийн жилд улсын хэмжээнд нийт 1067 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаагаас 303 нь хувийн хэвшлийнх, ерөнхий боловсролын 756 сургууль байгаагаас 128 нь буюу 16,9% нь хувийн хэвшлийн сургууль байна.

112. Гадаадад ажиллаж, амьдарч буй иргэдийн хүүхдүүд төрөлх монгол хэлээ мартаггүй байх, сурах боломжийг хангах үүднээс монгол хэлний сурах бичгүүдийг хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газруудаар дамжуулан олгох ажлыг хэрэгжүүлж байна.

### **М. Хөдөлмөрлөх эрхийг хангах чиглэлээр**

113. Хөдөлмөрийн тухай хуульд “Адил хөдөлмөр эрхэлж байгаа эрэгтэй, эмэгтэй ажилтанд адил хэмжээний цалин хөлс тогтооно” гэж заасан боловч Тэгш шан хөлс олгох тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллага (цаашид “ОУХБ” гэх)–ын 100 дугаар конвенцийн “адил үнэлэмжтэй хөдөлмөр эрхэлж байгаа эрэгтэй, эмэгтэй ажилтанд тэгш шан хөлс олгох” гэсэн зарчим тусгагдаагүй байгаа. Энэ зарчмыг Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан.

114. Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албан хаагчдын цалин хөлсийг хүйсийн байдал харгалзахгүйгээр Засгийн газраас албан тушаалын ангилал, зэрэглэлийг харгалзан тогтоосон цалингийн шатлалын дагуу олгож байна.

115. Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хороо “Аж ахуйн нэгж, байгууллагад цалин хөлсний талаар баримтлах зөвлөмж” баталсан бөгөөд зөвлөмжид ажлын үнэлгээ хийх аргыг тодорхойлж, үнэлгээний дагуу ажлын зэрэглэл, түвшинг гаргахаар заасан. Цөөн тооны томоохон аж ахуйн нэгж, байгууллагын хувьд энэ ажлын

зэрэглэл, цалингийн сүлжээг баримталж хамтын гэрээ, хэлэлцээрт тусган цалин хөлсийг олгож байгаа боловч дийлэнх аж ахуйн нэгж, байгууллагын хувьд энэ зөвлөмжийг мөрдөхгүй байна. Мөн цалингийн хэлэлцээр байгуулах чадавхийг салбарын түншлэгч байгууллагуудад бий болгох чиглэлээр ОУХБ-тай хамтран ажиллаж, эхний ээлжинд уул уурхай, барилгын салбарын байгууллагад ийм чадавхийг бүрдүүлэх ажлыг эхлүүлээд байна.

116. Хөдөлмөрийн яам 2014 онд мэргэжлийн ур чадваргүй, ажилгүй иргэдэд богино хугацаанд мэргэжил олгох зорилготой Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр, Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр, 40-өөс дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, Аж ахуй эрхлэлтийг хөгжүүлэх хөтөлбөр, Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, Оюутны хөдөлмөр эрхлэлт ба цагийн ажил хөтөлбөр, Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ төслийг тус тус хэрэгжүүлж байна.

117. Түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй ажилгүй иргэдийг түр ажлын байраар хангах, нийтийг хамарсан ажилд оролцуулах, ногоон ажлын байр бий болгох зорилготой Эзэнтэй Монгол хөтөлбөр хэрэгжүүлж байна.

#### **Н. Ядуурал, хүнсний аюулгүй байдлын хангах чиглэлээр**

118. Статистик мэдээллээр ядуурлын түвшин 2010 онд 38.7 хувьд хүрч байсан бол 2012 оны эцсийн байдлаар 27.4 хувь болсон. Үүнээс хөдөөд 35.5 хувь, хот, суурин газарт 23.2 хувьтай байна.

119. Ядуурлыг бууруулах, хүнсний хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулийг 2012 онд шинэчлэн баталж, Органик хүнсний тухай хууль, Органик хүнсний үйлдвэрлэлийг дэмжих үндэсний хөтөлбөр, Органик хүнсний үйлдвэрлэлд хэрэглэх бодисын жагсаалтын төслийг тус тус боловсруулаад байна. Мөн хүнсний аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор Засгийн газраас 2016 он хүртэл хэрэгжүүлэх Хүнсний аюулгүй байдал үндэсний хөтөлбөрийг 2009 онд батлан хэрэгжүүлж байна.

120. Монгол Улсын нийт 794090 өрхийг амьжиргааны түвшингээр эрэмбэлсэн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж нийгмийн халамж, дэмжлэг зайлшгүй шаардлагатай 16822 өрх буюу өрхийн 2 хувьд хүнсний талон сар бүр олгож байна.

121. 2014 оны байдлаар Монгол Улсад хүн амын хоол тэжээлийн байдлыг илтгэгч 5 хүртэлх насны хүүхдийн дунд өсөлтийн хоцролт 10.8%, тураал 1.6%, туранхай 1.0%-тай болон буурснаар өлсгөлөн, хоол тэжээлийн дуталтай хүн амын тоог 2015 онд 1990 оны түвшнээс 6 дахин бууруулах зорилтодоо хүрсэн. Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын “Үдийн цай хөтөлбөр” хэрэгжсэнээр ядуу, орлого багатай өрхийн хүүхдийн сургууль завсардалт буурч, хүнсний хомсдол, дутагдал багассан.

#### **О. Байгаль орчны бохирдол, аюулгүй байдлын хангах чиглэлээр**

122. Байгаль орчны эрх зүйн орчинг сайжруулах, байгаль орчны салбарын 18 хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, уялдаа холбоог сайжруулах үүднээс 2012

онд салбарын 15 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Ус бохирдуулсны төлбөрийн тухай, Хөрс хамгаалах, цөлжилтөөс хамгаалах тухай хуулиудыг шинээр батлан мөрдөж байна.

123. Эдгээр хуулиудын хүрээнд байгаль орчны тэнцвэрт байдлыг алдагдуулсан, хохирол учруулсан этгээд нөхөн төлбөр төлөх замаар хохирлыг арилгах, мөн байгаль орчныг нөхөн сэргээх хуримтлалын сан бий болж аймаг нийслэлд төвлөрөх байгалийн нөөцийн төлбөрийн орлогын 55–аас доошгүй хувиар байгаль хамгаалах, орчны доройтлыг бууруулах боломж бүрдсэн. Мөн нутгийн иргэд байгаль хамгаалах, байгалийн баялгийн үр шимийг давуу эрхтэй ашиглах боломжтой болсон.

124. Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний хөтөлбөрийг 2011 онд баталж, хөтөлбөрийн хүрээнд НҮБХХ, Дасан зохицох сангийн дэмжлэгээр Экосистемд түшиглэсэн дасан зохицох арга хэмжээг уур амьсгалын өөрчлөлтөд өндөр эрсдэлтэй голын сав газарт хэрэгжүүлэх 5,5 сая ам.долларын санхүүжилттэй төслийг хэрэгжүүлж байна.

125. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, НҮБХХ–ийн газартай хамтран ус, ариун цэврийн байгууламжийн асуудал эрхэлсэн байгууллагуудын удирдлага, зохион байгуулалт, бүтцийг сайжруулах, орон нутгийн иргэдийг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны ус, сайжруулсан ариун цэврийн байгууламжаар хангах зорилготой Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр (2008–2013) Говь–Алтай, Баянхонгор, Өмнөговь аймгуудад хэрэгжүүлсэн.

#### **V. Хүндрэл бэрхшээл, гарах арга зам**

126. Хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр эрх бүхий байгууллагаас хууль, тогтоомж баримт бичгүүд батлагдан гарсан ч хуулийг бүрэн хэрэгжүүлэх боловсон хүчин, чадавхыг сайжруулах шаардлага байна. Мөн санхүү төсөв шаардлагатай хэмжээнд хүрэхгүй байна.

#### **Vi. Тэргүүлэх ач холбогдол өгч буй асуудал**

127. Тайлангийн хугацаанд Монгол Улс зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэв. Тухайлбал олон улсын гэрээнд нэгдэх, хүний тодорхой төрлийн эрхийн асуудлаар тухайлсан хуулийг батлах чиглэлд томоохон ахиц гарсан. Цаашид хууль сахиулах байгууллагын чадавхийг сайжруулах, олон нийтэд хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх нь нэн тэргүүний асуудал болж байна.



**9.5 МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТАЛААРХ ҮНДЭСНИЙ  
ХОЁРДУГААР ИЛТГЭЛИЙГ ХЭЛЭЛЦЭЭД НҮБ-ЫН ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨВЛӨЛӨӨС  
ӨГСӨН ЗӨВЛӨМЖ**

№	Санал, зөвлөмжүүд	Зөвлөмж өгсөн улс
1.	Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенцийн 14 дүгээр зүйлийг хүлээн зөвшөөрч, мэдэгдэл хийх	Эстони
2.	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколоор хүлээсэн үүргээ биелүүлэхэд чиглэсэн шаардлагатай бүх арга хэмжээг авах	Намиби
3.	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколд нийцүүлэн цаазаар авах ялыг халах зорилгоор үндэсний хууль тогтоомжид боломжит хурдан хугацаанд өөрчлөлт оруулах	Потугал
4.	Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 21, 22 дугаар зүйлүүдийг соёрхон батлах	Алжир
5.	Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн 21, 22 дугаар зүйлүүдэд заасны дагуу Эрүү шүүлтийн эсрэг хорооны эрх хэмжээг хүлээн зөвшөөрч, мэдэгдэл хийх	Польш
6.	Эрүү шүүлтийн эсрэг хорооны хувь хүнээс мэдээлэл авах эрх хэмжээг хүлээн зөвшөөрөх зорилгоор Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 22 дугаар зүйлд заасан мэдэгдэл хийх	Дани
7.	Эрүүдэн шүүхийн эсрэг нэмэлт протоколд нийцүүлэн зохих чадамж, нөөц бололцоотой үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагыг байгуулах	Чех
8.	Хүүхдийн эрхийн тухай конвенцийн Мэдээлэл хүргүүлэх журмын тухай нэмэлт протоколыг соёрхон батлах	Монтенегро; Португал; Тайланд
9.	Нийт цагаач ажилчид болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенцийг соёрхон батлах тухай	Парагвай
10.	Нийт цагаач ажилчид болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенцид нэгдэн орох	Уругвай

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

№	Санал, зөвлөмжүүд	Зөвлөмж өгсөн улс
11.	Нийт цагаач ажилчид болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенцийг соёрхон батлах явцыг хурдасгах конвенцийг соёрхон батлах асуудлыг судлан үзэх	Алжир
12.	Нийт цагаач ажилчид болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенц, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 189 дүгээр конвенцийг соёрхон батлах асуудлыг судлан үзэх	Филиппин
13.	Цагаач ажилчдын эрхийн асуудалд цогц байдлаар хандах зорилгоор Нийт цагаач ажилчид болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенцид нэгдэн орох асуудлыг судлан үзэх	Индонези
14.	Нийт цагаач ажилчид болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенц, Дүрвэгсдийн болон Харьяалалгүй хүний эрх зүйн байдлын тухай конвенциудыг соёрхон батлах	Сиерра Леон
15.	Харьяалалгүй хүний эрх зүйн байдлын тухай конвенц, Хүн Норвеги харьяалалгүй байх явдлыг бууруулах тухай конвенцид нэгдэн орох асуудлыг нааштайгаар судлан үзэх	Норвеги
16.	Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай 1951 оны конвенц, уг конвенцийн 1967 оны протоколд нэгдэн орох явцыг хурдасгах, аль улсаас гаралтайг нь үл хамааран орогнол хүсэгч болон дүрвэгсдийг хамгаалсан хууль тогтоомж батлах	Канад
17.	Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэмд үндэсний хууль тогтоомжоо бүрэн нийцүүлэх, Олон улсын эрүүгийн шүүхийн Эр ямба, дархан эрхийн тухай конвенцийг соёрхон батлах	Эстони
18.	Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрмийн зохицуулалтыг үндэсний хууль тогтоомждоо тусгах	Португал
19.	Яс үндэс, шашин, бэлгийн чиг баримжаа, эсхүл хүйсийн байдал, хэл, улс төрийн үзэл бодол, сэтгэл зүйн, эсхүл биеийн хөгжлийн бэрхшээлийн улмаас ялгаварлан гадуурхагдах бүх хэлбэрээс зайлсхийх зорилгоор ялгаваран гадуурхахын эсрэг тухайлсан иж бүрэн хууль тогтоомжийг батлах	Чили
20.	Ялгаварлан гадуурхахтай тэмцэх тухайлсан иж бүрэн хууль тогтоомжийг батлах, ийнхүү батлах хууль тогтоомж, эсхүл одоо байгаа хуулиар тогтоосон тэгш байдлыг бодит амьдралд хангах нөхцлийг бүрдүүлэх	Ирланд

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

№	Санал, зөвлөмжүүд	Зөвлөмж өгсөн улс
21.	ЛГБТ хүмүүс зэрэг нийгмийн цөөнх бүлгүүдийн нийт гишүүний эрхийг хамгаалах ялгаварлан гадуурхахын эсрэг иж бүрэн хууль тогтоомжийг батлах	Англи
22.	Эрүүгийн шинэ хуулиа батлах явцаа хурдасгах	Турк
23.	Хүн бүрийн эрх тэгш болон аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин, хүний эрхийн соёлыг бүрдүүлэх үүднээс Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулах, эрх зүйн бусад орчноо сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй нааштай ажлаа үргэлжлүүлж, батлагдах хуулиа үр нөлөөтэй хэрэгжүүлэх	Норвеги
24.	Хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настай хүмүүс, ОХУ эмэгтэйчүүд зэрэг хүн амын эмзэг бүлгийн эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих ажлаа үргэлжлүүлэх	
25.	Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулиа өөрчлөн, Парисын зарчимд нийцэхүйц түвшинд комиссын чадавхийг сайжруулах	Сиерра Леон
26.	Боловсрол, хүний эрхийн сургалтын салбарт, тэр дундаа хууль сахиулах албан хаагчдыг сургах чиглэлд гаргаж буй хүчин чармайлтаа үргэлжүүлэх	Морокко
27.	Шүүгч, магистратуудын байнгын болон зайлшгүй хамрагдах сургалтын хөтөлбөрүүдэд хүний эрхийн сургалт болон олон улсын гэрээний хэрэглээний сургалтыг оруулах	Мексик
28.	Бие даасан байдлыг нь бүрэн хангах, Парисын зарчимд нийцүүлэх үүднээс Хүний эрхийн үндэсний комиссын мандатыг бэхжүүлэх	Чили
29.	Бие даасан байдлыг нь хангах үүднээс Хүний эрхийн үндэсний комисст одоогийн түвшнээс илүүтэй дэмжлэг үзүүлэх	Австрали
30.	Хүний эрхийн чиглэлээрх үндэсний байгууллагууд, тогтолцоогоо бэхжүүлж буй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх	Непал
31.	Парисын зарчмын дагуу мандатаа чөлөөтэй, бие даасан байдлаар хэрэгжүүлэх бололцоог Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст олгох зорилгоор комиссын чадавхийг өргөжүүлэн бэхжүүлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авах	Намиби
32.	Хүний эрхийн Үндэсний Комисс Парисын зарчмын шаардлагуудыг хангаж байх үүднээс түүний үйл ажиллагааг сайжруулж, ялгаварлан гадуурхахын эсрэг тэмцлийг сайжруулах үүднээс комиссын эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийг хангах	Нигер

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

№	Санал, зөвлөмжүүд	Зөвлөмж өгсөн улс
33.	Монгол Улс дахь хүний бүх эрхийг үр нөлөөтэй байдлаар эдлүүлэх зорилгоор хүний эрхийн чиглэлээрх байгууллагуудыг улам бэхжүүлэх үйл ажиллагаа, хүчин чармайлтаа үргэлжлүүлэх	Пакистан
34.	Хүүхдүүд, ахмад иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг хамгийн эмзэг бүлгийн иргэдийн эрхийг хамгаалах үндэсний хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэх амлалт, үүргээ биелүүлэх	Румын
35.	Засгийн газрын чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагуудыг оролцуулан бүх түвшинд хүний эрхийн боловсрол олгох, сургах хүчин чармайлтаа үргэлжлүүлэх	Пакистан
36.	Ээлжит нэгдсэн хэлэлцүүлгийн зөвлөмжийг оролцуулан олон улсын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх тогтолцоог бий болгох боломжийг судлан үзэх	Парагвай
37.	Хүний эрхийн салбар дахь олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр ажиллах	Туркменистан
38.	2003 онд хүргүүлэх байсан ч одоог хүртэл хүргүүлээгүй байгаа анхдугаар илтгэлээ НҮБ-ын Эрүү шүүлтийн эсрэг хороонд хүргүүлж, хороотой үр нөлөөтэй хэлэлцүүлэг эхлүүлэх бололцоог олгох	Дани
39.	Хүний эрхийн зөвлөлийн Тусгай процедур болон гэрээний байгууллагууд зэрэг олон улсын хүний эрхийн чиглэлээрх хяналтын механизмуудтай хамтын ажиллагаагаа сайжруулах, өргөжүүлэх асуудлыг судлан үзэх	Туркменистан
40.	Хүний эрхийн салбар дахь техникийн туслалцааны болон чадавхийг сайжруулах олон улсын хөтөлбөрүүдэд идэвхитэй оролцох	Туркменистан
41.	Аливаа шалтгаанаар ялгаварлан гадуурхахтай тэмцэх шинэ хууль тогтоомжийг батлах	Уругвай
42.	Бүх төрлийн шалтгаанаар ялгаварлан гадуурхахын эсрэг, түүний дотор хохирогчдын эрхийг хамгаалсан иж бүрэн хууль батлах	Чех
43.	Хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах чиглэлээрх арга хэмжээнүүдээ үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Япон
44.	Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн үүрэг, хариуцлагын талаарх нийгмийн ойлголтыг өөрчлөх, ялгаварлан гадуурхах уламжлалт хандлагын асуудлыг шийдвэрлэх хүрээнд авч буй арга хэмжээнийхээ үр нөлөөг бэхжүүлэх хүчин чармайлтаа нэмэгдүүлэх	Словени

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

№	Санал, зөвлөмжүүд	Зөвлөмж өгсөн улс
45.	Эмэгтэйчүүдэд тэгш байдал, хамгаалалтыг олгож буй хууль тогтоомжийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх нөхцлийг хангах арга хэмжээнүүдийг гүнзгийрүүлэх	Аргентина
46.	Эмэгтэйчүүдийн эрхийн хамгаалалтыг сайжруулах чиглэлээрх хүчин чармайлтаа үргэлжлүүлэх	БНСУ
47.	Нийтийн албан дахь эмэгтэйчүүдийн оролцоо, жөндөрийн тэгш байдлыг үргэлжүүлэн дэмжих	Лаос
48.	Монгол Улсын нийгэм, эдийн засгийн амьдрал дахь эмэгтэйчүүдийн бүх талын, идэвхитэй оролцоог улам бэхжүүлэх бодлогоо үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Сингапур
49.	Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдлын асуудлаарх Аюулгүйн зөвлөлийн 1325 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх үндэсний төлөвлөгөө батлах асуудлыг судлан үзэх	Португал
50.	Арьс өнгө, яс үндсээр ялгаварлан гадуурхахыг өдөөн хатгасан үзэн ядах үг хэлэх үйлдэлтэй болон үүнээс улбаатай хүчирхийллийн эсрэг тэмцэх	БНХАУ
51.	Гэр хорооллын дүүргүүдэд амьдарч буй хүмүүсийг шууд болон шууд бусаар ялгаварлан гадуурхах явдалтай тэмцэх үр нөлөөтэй арга хэмжээнүүдийг авах	Швед
52.	Гадаадын иргэдийг аливаа хэлбэрийн халдлагаас хамгаалах, гэмт этгээдэд хариуцлага оногдуулах чиглэлээрх хүчин чармайлтаа ахиулах	БНСУ
53.	Бэлгийн чиг баримжаа, эсхүл бэлгийн байдалд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтыг оролцуулан ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэртэй тэмцэх	Франц
54.	ЛГБТИ хүмүүсийн хүний эрхийн үр нөлөө бүхий хамгаалалт тогтоосон хууль тогтоомжийг боловсруулж батлахаас гадна Нэн ядуурал ба хүний эрхийн асуудлаарх Тусгай илтгэгчийн илтгэлд дурдсан ЛГБТ хүмүүсийн эсрэг үйлдсэн гэх халдлагуудыг хараат бус байдлаар мөрдөн шалгах арга хэмжээ авах	Гондурас
55.	Бэлгийн чиг баримжаа, хүйсийн байдалд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтыг оролцуулан ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэрийг хориглох	Словени

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

№	Санал, зөвлөмжүүд	Зөвлөмж өгсөн улс
56.	Бэлгийн чиг баримжаа, хүйсийн байдал болон эрүүл мэндийн байдалд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтыг оролцуулан ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэрийг хориглох	Зүүн Тимор
57.	Өөрийн үндэсний хууль тогтоомждоо тусган оруулах замаар ЛГБТИ хүмүүс эрхээ эдлэх тэгш байдлыг хөхиүлэн дэмжих	Уругвай
58.	Үзэн ядах, бэлгийн чиг баримжаа, хүйсийн байдалд үндэслэсэн ялгаварлан гадуурхах гэмт хэргүүдийг эрүүгийн хууль тогтоомждоо оруулах зорилгоор тухайн хууль тогтоомжийг өөрчлөх	Испани
59.	ЛГБТ хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхалт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, ийм явдлыг үл тэвчих хандлагыг дэмжих зорилгоор олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх сурталчилгааны ажлыг зохион байгуулах	Бразил
60.	Бэлгийн чиг баримжаа, хүйсийн байдалд үндэслэсэн ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлтэй тэмцэх хүчин чармайлтаа сайжруулж, энэ чиглэлээрх датаг цуглуулах, мэдээлэл, статистикийг гаргах ажлыг зохион байгуулалттайгаар хийж гүйцэтгэх	Нидерланд
61.	Өмнөх удаа зөвлөмж болгож байсанчлан ХДХВ/ДОХ-той статуст үндэслэсэн ялгаварлан гадуурхалтыг оролцуулан аливаа үндэслэлээр ялгаварлан гадуурхах явдлыг илэрхий хориглох, гарахаас урьдчилан сэргийлэх, шийтгэх, болон халах зорилгоор үр нөлөөтэй, хойшлуулшгүй арга хэмжээ авах, мөн шаардлагатай хууль тогтоомжийг батлах	Мексик
62.	Монгол Улс соёрхон баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын Цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт II протоколд нийцүүлэн цаазаар авах ялыг халж хуульчлан баталгаажуулах	Франц
63.	Цаазаар авах ялыг илэрхий халсан хууль тогтоомж батлах	Австрали
64.	Цаазаар авах ялыг бүрэн халах зорилгоор Эрүүгийн хуулиа өөрчлөх	Итали
65.	Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд цаазаар авах ялыг эцэслэн халах	Англи
66.	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколыг соёрхон баталснаар хүлээсэн олон улсын үүргээ биелүүлэх үүднээс цаазаар авах ялыг халах хүрээнд эрүүгийн хууль тогтоомжоо шинэчлэх	Швед
67.	Цаазаар авах ялыг хуулиар халах зорилгоор шинэ Эрүүгийн хуулийг оролцуулан шаардлагатай хууль тогтоомжийг батлах	Словак

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

№	Санал, зөвлөмжүүд	Зөвлөмж өгсөн улс
68.	Бүх төрлийн гэмт хэрэгт цаазаар авах ялыг de jure байдлаар оногдуулахгүй болгож халах	Монтенегро
69.	Цаазаар авах ялыг халж, цаазаар авахуулсан хүмүүсийн гэр бүлд цаазаар авсан тухай мэдээллийг ил болгож өгөх	Литва
70.	Цаазаар авах ялын гүйцэтгэлийг улсын нууц мэдээллээс гаргах	Португал
71.	Хууль сахиулах албан хаагчид болон нийтийн бусад албан хаагчдын сургалтын хөтөлбөр, мөн шүүгч, хуульч нарын байнгын сургалтын хөтөлбөрт эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх олон улсын зохицуулалтыг тусган оруулах	Мексик
72.	Эрүүдэн шүүсэн байж болзошгүй бүх хэргийг мөрдөн шалгах, хорих байрны болон шоронгын барилга байгууламжийн нөхцлийг сайжруулах, эрүүдэн шүүгдсэний улмаас хохирсон хохирогчдод эдлэх эрх зүйн хамгаалалтыг бэхжүүлэх	Чех
73.	Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх үүднээс цагдаагийн албан хаагчдад тухайлан зориулсан ойлголтыг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх, мөн энэ хэрэгт ял шийтгэлгүй үлдэх явдалтай тэмцэх үүднээс мөрдөн шалгах үр нөлөө бүхий тогтолцоог бий болгох	Франц
74.	Эрүүдэн шүүх үйлдлийг гэмт хэрэг хэмээн тодорхойлсон тодорхойлолтыг Эрүүгийн хуульд тусган оруулах үүднээс тухайн хуульдаа өөрчлөлт оруулах асуудлыг судлан үзэх	Унгар
75.	Соёрхон батлаад удаагүй байгаа Эрүүдэн шүүхийн эсрэг нэмэлт протоколд заасан шаардлагын дагуу эрүүдэн шүүсэн болон зүй бусаар харьцсан байж болзошгүй хэргийг мөрдөн шалгах бие даасан тогтолцоог байгуулах	Австри
76.	Нийтийн албан хаагч эрүүдэн шүүх болон зүй бусаар харьцах үйлдлийг үл тэвчих, эрүүдэн шүүсэн байж болзошгүй бүх сэжигтэй этгээдийг заавал мөрдөн шалгах нөхцлийг бүрдүүлэх	Зүүн Тимор
77.	Цагдаагийн албан хаагч эрүүдэн шүүсэн болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг нь доромжлон харьцсан байж болзошгүй үйлдлийг мөрдөн шалгах бие даасан тогтолцоог бий болгож, нийтийн албан хаагч ийм төрлийн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх	Швейцар

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

№	Санал, зөвлөмжүүд	Зөвлөмж өгсөн улс
78.	Эрүүдэн шүүсэн болон зүй бусаар харьцсан байж болзошгүй талаарх бүх гомдол, мэдээллийг бие даасан агентлаг бүрэн гүйцэд мөрдөн шалгадаг байх, тухайн үйлдлийг үйлдсэн этгээд хариуцлага хүлээдэг байх, түүнчлэн мөрдөн шалгалтыг зохих эрх мэдэлтэй, хараат бус болон сэжиглэгдэж буй этгээд, тэдгээрийн ажилладаг байгууллагад хамааралгүй бие даасан этгээд хийх нөхцлийг бүрдүүлэх	Швед
79.	Нийтийн албан хаагч эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх үүднээс үйлдсэн байж болзошгүй бүх хэргийг цаг алдалгүй, бүрэн гүйцэд шалгах нөхцлийг хангахад чиглэсэн арга хэмжээнүүдийг бэхжүүлэх	Итали
80.	Эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах бусад үйлдлийг алга болгох арга хэмжээнүүд, түүний дотор хууль сахиулах эрх бүхий албан тушаалтнуудыг сургах, боловсрол олгох зэрэг арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн авах	Коста Рика
81.	Эрүүдэн шүүсэн, цагдаагийн албан хаагчийн хэрцгий байдал болон үндэслэлгүйгээр баривчилсан байж болзошгүй үйлдлүүдийг мөрдөн шалгах шүүхийн болон бусад тогтолцоог бий болгох	Канад
82.	Хоригдож буй хүмүүстэй харьцах нөхцлийг сайжруулахад чиглэсэн зохих алхмуудыг авах	Япон
83.	Хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хууль тогтоомж батлах	Зүүн Тимор
84.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээрх идэвхитэй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх	Беларус
85.	Гэр бүлийн хүчирхийллийг халах хүчин чармайлтаа улам идэвхижүүлэх	Филиппин
86.	Гэр бүлийн болон жендэрт тулгуурласан хүчирхийлэл, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг халах чиглэлээр илүү хүчин чармайлт гарган ажиллах, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэх замаар нийгмийн бүх салбар дахь эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх	БНСУ



**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

№	Санал, зөвлөмжүүд	Зөвлөмж өгсөн улс
87.	Гэр бүлийн хүчин, бэлгийн дарамтыг эрүүгийн хэрэгт тооцох, хохирогчид шүүхэд хандах, туслалцаа болон хамгаалалт авах эрхийг нь эдлүүлэх, ийм төрлийн хэргийг зохих ёсоор мөрдөн шалгах, гэмт этгээд ял шийтгэл хүлээх нөхцлийг хангах замаар жендэрт тулгуурласан болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хүчин чармайлтаа бэхжүүлэх	Словени
88.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх ажлыг дэмжихүйц эмэгтэйчүүдийн эсрэг бүх төрлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний тухайлсан стратеги баталж идэвхитэй хэрэгжүүлэх	Турк
89.	Гэр бүлийн хүчирхийллээс амьд үлдсэн хүмүүсийн хамгаалалтыг улам сайжруулах, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, түүний шалтгаан, үр дагаварын асуудлаар Тусгай илтгэгч Монгол Улс хүлээн авах урилга хүргүүлэх	АНУ
90.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээрх хүчин чармайлтаа үргэлжлүүлэх	Латви
91.	Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, мөрдөн шалгах тогтолцоог ажиллуулах, энэ төрлийн хэргийг шийдвэрлэх асуудлаар хууль сахиулах албан хаагчдыг сургах	Молдав
92.	Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг одоогийн хуулиа үр нөлөөтэй хэрэгжүүлэх, алслагдсан газруудад хамгаалалтын байр барих зэргээр хохирогчдыг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг бэхжүүлэх	Швейцари
93.	Гэр бүлийн хүчирхийллийг эрүүгийн хэрэгт тооцох, хохирогчдыг хамгаалах хамгаалалтыг сайжруулах, гэмт этгээдэд ял шийтгэл оногдуулах зорилгоор Парламентаар хэлэлцэж буй гэр бүлийн хүчирхийллийн хуулийн төслийг батлах	Австрали
94.	Гэр бүлийн хүчирхийллийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх ажилд тусгайлан анхаарал хандуулах замаар гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх	Испани
95.	Холбогдох байгууллага хоорондын хамтын ажиллагааны уялдааг сайжруулах, нотлох баримтын шаардлагыг эргэж харах болон тусгаарласан шийдвэрийг хэрэгжих нөхцлийг хангах зэргээр гэр бүлийн хүчирхийллийн эсрэг эрх зүйн хамгаалалтыг авахад учирж буй саад тотгорыг арилгах	Австри

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

№	Санал, зөвлөмжүүд	Зөвлөмж өгсөн улс
96.	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үр нөлөө бүхий хамгаалалт авах, эрхээ сэргээлэх боломжийг сайжруулах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэм буруутныг яллах чадавхийг бэхжүүлэх, гэр бүлийн хүчинг эрүүгийн хэрэгт тооцох	Чех
97.	Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, тэдний эсрэг хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд чиглэсэн одоогийн хууль тогтоомжийн үр нөлөөтэй хэрэгжилтийг хангах	Итали
98.	Гэр бүлийн хүчирхийллээс зугатан хамгаалалт хайж буй эмэгтэйчүүд, хүүхдүүдэд зориулсан хамгаалах байрыг илүү олноор барих боломжийг судлан үзэх	Малайз
99.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хууль тогтоомжоо улам бэхжүүлэх	ОХУ
100.	Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэмцэх эрх зүйн маш тодорхой орчныг бүрдүүлэх, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод зориулсан нийгмийн хамгааллын тогтолцоог бий болгох	Серби
101.	Гэр бүлийн хүчирхийллийг эрүүгийн хэрэгт тооцох өөрчлөлтийг эрүүгийн хууль тогтоомждоо оруулах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэмт этгээдэд эрх бүхий байгууллагууд хариуцлага хүлээлгэн яллах нөхцлийг хангах, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод шаардлагатай бүх төрлийн үйлчилгээнд хангалттай санхүүжилт олгох	Словак
102.	Гэр бүлийн хүчирхийллийг эрүүгийн хэрэгт тооцох өөрчлөлтийг эрүүгийн хууль тогтоомждоо оруулах	Испани
103.	Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, гэр бүлийн хүчирхийллийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх сурталчилгааны ажлын цар хүрээг өсгөх, хохирогчдод үзүүлэх үйлчилгээ, хамгаалалтыг өргөжүүлэх	Канад
104.	Гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн дарамтыг эрүүгийн хэрэгт тооцох боломжийг судлан үзэх, гэмт этгээд эрүүгийн хариуцлага хүлээдэг болох нөхцлийг хангах	Унгар
105.	Гэр оронд учирч буй заналхийлэл, бэлгийн дарамт, мөлжлөг зэрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг оролцуулан гэр бүлийн хүчирхийллийг эрүүгийн хэрэгт тооцох хууль тогтоомж батлах, гэмт этгээд яллан шийтгэгддэг, хохирогчид, тэр дундаа орон нутагт буй хохирогчид халамж авдаг болох нөхцлүүдийг хангах	Парагвай

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

№	Санал, зөвлөмжүүд	Зөвлөмж өгсөн улс
106.	Эрүү шүүлтийн эсрэг хорооноос өгсөн зөвлөмжүүдийн дагуу хүүхдийн бие махбодийн шийтгэлийг илэрхий хориглох	Чили
107.	Гэр орон доторх шийтгэлийг оролцуулан хүүхдийн бие махбодийн бүх шийтгэлийг илэрхий хориглох	Швед
108.	Хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх үр нөлөө бүхий арга хэмжээнүүдийг авах, хүүхдийг мөлжлөгт автахаас, ялангуяа хөдөлмөрийн аюултай нөхцөл байдалд ажиллуулах мөлжлөгт автахаас хамгаалах	Герман
109.	Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах 2012–2016 оны үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах, хөтөлбөр хэрэгжсэний дараахь тогтолцоог судлан үзэх	Итали
110.	Хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх ажлаа өргөжүүлэх, хүүхэд хөдөлмөрийн аюултай нөхцөл байдалд, түүний дотор бичил (албан бус) уурхайд хөдөлмөр эрхлэхгүй байх нөхцлийг хангах	Итали
111.	Хүүхдийг хөдөлмөр эрхлүүлсэн ажил олгогчдод хариуцлага хүлээлгэх зэргээр хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх ажлаа үргэлжлүүлэх, гэр оронд болон сургуульд хүүхдэд хүлээлгэх хариуцлагын хүчирхийллийн бус шинэ хэлбэрүүдийг бий болгох	Литва
112.	Хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх стратегиудыг судлан тодорхойлох	Норвеги
113.	Хүүхдийн хөдөлмөрийг мөлжиж буй ажил олгогчдын үйлдлийг эрүүгийн хэрэгт тооцох, тэдэнд хариуцлага хүлээлгэх зэргээр хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх	Польш
114.	Хүүхдүүд бүх төрлийн хүчирхийлэл, мөлжлөгөөс, ялангуяа хөдөлмөрийн аюултай нөхцөл байдал дахь мөлжлөгөөс хамгаалагдсан байх нөхцлийг хангах чиглэлээрх хүчин чармайлтаа үргэлжлүүлэх	БНСУ
115.	Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээрх хүчин чармайлтаа үргэлжлүүлэх	Морокко
116.	Хууль сахиулах байгууллагын хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, гэмт этгээдийг яллах чадавхийг бэхжүүлэх, хохирогчдод үзүүлэх үйлчилгээг өргөжүүлэх замаар Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах	Канад

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

№	Санал, зөвлөмжүүд	Зөвлөмж өгсөн улс
117.	Хүн худалдаалахтай тэмцэх тухай 2012 оны хуулийг хэрэгжүүлж, гэмт этгээдийг мөрдөн шалгах, яллах ажиллагааны үр нөлөөтэй байдлыг хангах, хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх үүднээс хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагыг бэхжүүлэх	Бразил
118.	Хүн худалдаалахын эсрэг маш хатуу хууль батлах замаар хүүхдийг худалдаалах бүх хэлбэрийг эрүүгийн хэрэгт тооцох	Сиерра Леон
119.	Хүн худалдаалах бүх хэрэгт шаардлагатай мөрдөн шалгах, яллах ажиллагаа явуулах замаар хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдийг худалдаалахтай тэмцэх арга хэмжээгээ өргөжүүлэх	Малайз
120.	Хүн худалдаалахтай тэмцэхэд шаардлагатай боловсон хүчний болон материаллаг бүх нөөцийг хуваарилан олгох	Гондурас
121.	Хүн худалдаалах хэргийн хохирогч, гэрч эрх зүйн туслалцаа, хамгаалалт, нөхөн сэргээх үйлчилгээ авах боломжоор баталгаатай хангагдах нөхцлийг бүрдүүлэхэд шаардлагатай төсвийн, захиргааны болон эрх зүйн арга хэмжээнүүдийг авах	Мексик
122.	Хүн худалдаалахын эсрэг хөтөлбөрт шаардлагатай боловсон хүчний болон бусад нөөцийг хангалттай байдлаар үргэлжлүүлэн олгох	Филиппин
123.	Эрх зүйн шинэ орчин буюу Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд заасны дагуу хүн худалдаалах үйлдэлд ял оногдуулах, хууль сахиулах албан хаагчдын үйлдсэн хэргийг оролцуулан хүн худалдаалах хэрэг үйлдсэн байж болзошгүй бүх үйлдлийг мөрдөн шалгах, хохирогчдод нөхөн төлбөр олгох, нөхөн сэргээх зохицуулалтыг хэрэгжүүлэх зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй бүх талд зориулсан сургалт зохион байгуулах	Мексик
124.	Шүүх эрх мэдлийн тогтолцоог Монгол Улсын олон улсын амлалт, үүрэгт нийцсэн байдлаар шинэчлэх ажлаа үргэлжлүүлэх	ОХУ
125.	Бүх аймагт байгуулагдсан Хууль зүйн туслалцааны төвүүдийг шаардлагатай санхүүжилт, шалгуур хангасан боловсон хүчнээр хангах замаар эрх зүйн туслалцаа авах боломжийг нэмэгдүүлэх	Литва
126.	Эрүүдэн шүүсэн, зүй бусаар харьцсан хэрэг үйлдсэн этгээд ял шийтгэлгүй үлдэх явдалтай тэмцэх, эрүүдэн шүүгдсэний улмаас хохирсон хохирогчид хангалттай хэмжээний нөхөн олговор болон нөхөн сэргээх үйлчилгээ авах нөхцлийг хангах үүднээс эрүүдэн шүүсэн болон зүй бусаар харьцсан байж болзошгүй хэрэгт бие даасан, үр нөлөө бүхий мөрдөн шалгах ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэх	Герман

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

№	Санал, зөвлөмжүүд	Зөвлөмж өгсөн улс
127.	Бүх гэмт этгээдэд ял оногдуулах, хохирогчид цаг алдалгүй эрхээ сэргээлгэх, хамгаалалт авах нөхцлийг бүрдүүлэх	Литва
128.	Насанд хүрээгүй хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх цогц тогтолцоог олон улсын стандартад нийцүүлэн бий болгох	Сиерра Леон
129.	Иргэддээ тогтвортой хөгжил, тэгш байдлыг бүрдүүлэх үүднээс авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх арга хэмжээгээ үргэлжлүүлэн авах	Сингапур
130.	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тогтолцоон дахь авлигын бүх хэргийг мөрдөн шалгах	Литва
131.	Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн харилцааг зохицуулсан үндэсний хууль тогтоомжоо Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад нийцүүлэх, Харилцаа, холбооны зохицуулах хорооны бие даасан байдлыг хангах	Швейцар
132.	Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн харилцааг зохицуулсан хууль, журмуудаа Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын дагуу хүлээсэн Монгол Улсын үүрэгт нийцүүлэх, доромжлох үйлдлийг эрүүгийн хэрэгт тооцохгүй байх асуудлыг судлан үзэх	АНУ
133.	Интернет орчинг оролцуулан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг бүх орчинд баталгаатай эдлүүлэх	Франц
134.	Интернетийн зохицуулалтын бүх хүрээнд хүн хувийн нууцтай байх болон үзэл бодлоо илэрхийлэх эрхээ баталгаатай эдлэх боломжийг хангах зэргээр хүний эрхүүдэд хүндэтгэлтэй хандах, эдгээр эрх чөлөөг хязгаарлахдаа хууль зүйн үндэслэлтэй байх, зайлшгүй хэрэгцээтэй байх болон хамрах хүрээ нь зөв тодорхойлогдсон байх зарчмуудад нийцүүлэх нөхцлүүдийг хангах	Герман
135.	Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд болон иргэний нийгмийн зүтгэлтнүүд өөрсдийн үйл ажиллагаагаа олон улсын стандартад заасны дагуу шийтгэн цээрлүүлэх аливаа айдасгүйгээр чөлөөтэй эрхлэх бололцоог хангах	Эстони
136.	Доромжлох үйлдлийг эрүүгийн хэрэгт тооцохгүй болгох, төрийн болон орон нутгийн эрх бүхий байгууллагын үйл ажиллагааны талаар мэдээлсэн, эсхүл шүүмжилсэн үйлдлийн улмаас мөрдөн хавчигдах, эсхүл дарамтанд орохгүй байхаас хамгаалсан хамгаалалтыг бий болгох	Чех

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

№	Санал, зөвлөмжүүд	Зөвлөмж өгсөн улс
137.	Доромжлох үйлдлийг эрүүгийн хэрэгт тооцохгүй болгож, олон улсын хүний эрхийн стандартуудад нийцүүлэн иргэний хэрэг болгон өөрчлөх	Ирланд
138.	Эрүүгийн хуулийн доромжлох заалтыг шүүмжлэлийг дуугүй болгох зорилгоор ашиглахгүй байх, сэтгүүлчдийн мэдээллийн сурвалж болон мэдээллийг дотроос нь задруулагчдыг хамгаалах нөхцлийг бүрдүүлэх	Австри
139.	Эмэгтэйчүүдийн оролцоог улс төрийн шийдвэр гаргах түвшинд бэхжүүлэх зорилго бүхий үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх	Серби
140.	Эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах ажиллагаанд оролцуулах, өндөр түвшний албан тушаал эрхлүүлэх чиглэлээрх хүчин чармайлтаа бэхжүүлэх, боловсролын болон хөдөлмөрийн салбарт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулах нөхцлийг хангах	Норвеги
141.	Шийдвэр гаргах түвшний албан тушаал эрхлэх эмэгтэйчүүдийн төлөөллийг өсгөн нэмэгдүүлэх чиглэлээрх хүчин чармайлтаа эрчимжүүлэх	Рванда
142.	Шийдвэртэй арга хэмжээ авах, квотын шаардлага тогтоох зэрэг аргаар улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоог хангахад чиглэсэн арга хэмжээнүүд авах	Коста Рика
143.	Нийгмийн эмзэг бүлгийг хамруулан нийт хүн амын амьдралын чанарыг сайжруулах зорилгоор амжилттай хэрэгжиж буй нийгмийн хөтөлбөрүүдээ цаашид улам бэхжүүлэх	Венесуэл
144.	Хотын төвүүдэд нийгмийн хамгийн эмзэг бүлгийн хүмүүс, түүний дотор орон нутгаас шилжин ирсэн хүмүүс нийтийн суурь үйлчилгээ авах боломжтой байх нөхцлийг хангах замаар хотын төвүүдэд тогтвортой хөгжлийг бий болгоход чиглэсэн шаардлагатай арга хэмжээнүүдийг авах	Испани
145.	Эрүүл мэндийн суурь үйлчилгээг үндэсний болон бүсийн хэмжээнд үзүүлэх тогтолцоог бэхжүүлэх, үйлчилгээний хамрах хүрээ болон хүртээмжийг өсгөн нэмэгдүүлэх, эрүүл мэндийн тогтолцоонд буй хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх боломжуудыг судлан үзэх	Бутан
146.	Эмэгтэйчүүд, хүүхдүүдийн эрхийг хөхиүлэн дэмжих хүчин чармайлтаа үргэлжлүүлэх, одоог хүртэл өндөр түвшинд байгаа эхийн эндэгдлийг бууруулах чиглэлээр ажиллах	Непал

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

№	Санал, зөвлөмжүүд	Зөвлөмж өгсөн улс
147.	Эхийн эндэгдлийг бууруулах чиглэлээрх хүчин чармалтаа үргэлжлүүлэх	БНСУ
148.	Эхийн эндэгдлийн хувь хэмжээг, ялангуяа орон нутагт улам бууруулахад чиглэсэн бодит арга хэмжээнүүдээ үргэлжлүүлэн авах	Сингапур
149.	Орон нутаг болон хот суурин газар дахь хүүхдийн эндэгдлийн хувь хэмжээний зөрүүг бууруулах чиглэлээр хүчин чармайлт гарган ажиллах	Гондурас
150.	“Нэг Монгол” нээлттэй боловсролын үндэсний хөтөлбөрөө сайжруулан ажиллах	Латви
151.	Хүүхэд бүр сурч боловсрох эрхээ эдлэх нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн хүчин чармайлтаа үргэлжлүүлэх	Румын
152.	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөрийн харилцаан дахь оролцоог сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг өсгөн нэмэгдүүлэх, боловсрол эзэмших эрхээ эдлэх бололцоог нэмэгдүүлэхэд онцгой ач холбогдол өгөхүйц зохицуулалт бүхий тэдгээрийн эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд чиглэсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тухай хуулийн төслийг эцэслэн батлах ажилд гаргаж буй хүчин чармайлтаа хоёр дахин өсгөх	Индонези
153.	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлээрх нааштай хүчин чармайлтаа үргэлжлүүлэх	Аргентин
154.	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлээрх нааштай хүчин чармайлтаа үргэлжлүүлэх	Турк
155.	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон өндөр настай хүмүүсийн эрхийг онцгойлон анхаарсан зохицуулалт бүхий бүх төрлийн ялгаварлан гадуурхалтын асуудлыг зохицуулах тухайлсан хууль тогтоомж батлах	БНХАУ
156.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд эрүүл өсөн хөгжих нөхцлийг хангах зорилгоор боловсролын хөтөлбөрт эдгээр хүүхдийн боловсролын асуудлыг тусгайлан иж бүрэн байдлаар оруулж, ач холбогдол өгөх	Турк
157.	Боловсролын тогтолцоогоо улам бэхжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсрол эзэмших адил боломжтой байх нөхцлийг хангах	Лаос

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

№	Санал, зөвлөмжүүд	Зөвлөмж өгсөн улс
158.	Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, эмэгтэй хүүхдүүдийн эрхүүд, түүний дотор нөхөн үржихүй, хүчирхийллээс ангид байх, хөдөлмөр эрхлэх, боловсрох болон шийдвэр гаргах түвшинд оролцох эрхүүдэд онцгой ач холбогдол өгөх боломжийг судлан үзэх	Тайланд
159.	Буцаахгүй байх зэрэг олон улсын хэм хэмжээгээр тогтоосон шаардлагад нийцүүлэн орогнол хүсэгчдэд шаардлагатай хамгаалалтыг олгох, Дүрвэгсдийн конвенцийг соёрхон батлах асуудлыг судлан үзэх	БНСУ
160.	Орогнол хүсэгчид буцаахгүй байх зарчмын дагуух эрхээ болон бусад эрхээ эдлэх бололцоог нь хангах чиглэлээр Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Дээд комиссын газартай хамтран ажиллах	Уругвай
161.	Миниматагийн конвенцийг соёрхон батлах асуудлыг судлан үзэж, бичил уурхай эрхлэгчдийн эрхийг хамгаалах, тэдгээрийн үйл ажиллагааг аль болох хурдан хугацаанд албан ёсны болгох үүднээс бичил уурхайд үйлчилж буй Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.23 дахь заалтыг шинэчлэх	Унгар
162.	НҮБ-ын Бизнес болон хүний эрхийн асуудлаарх үндсэн зарчмыг хэрэгжүүлэх үүднээс нүүдэлчин малчдын нөхцөл байдал, эрхээ сэргээлгэх боломжийг сайжруулахад онцгой ач холбогдол өгсөн Бизнес болон хүний эрхийн асуудлаарх Үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр бий болгох	Нидерланд
163.	Олборлох үйлдвэрлэлийн салбарт аюулгүй байдлыг тогтоохдоо хүний эрхийг хангах зорилгоор Аюулгүй байдал, хүний эрхийн санаачилгын талаарх Сайн дурын зарчимд нэгдэх	АНУ
164.	Гар аргаар уурхай эрхэлж буй ажилчдын эрүүл мэндийг хамгаалах, байгаль орчныг хамгаалах зорилгоор тус салбар дахь мөнгөн усны хэрэглээг зохицуулсан үндэсний хөтөлбөр баталж хэрэгжүүлэх	Швейцар



## 9.6 ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ДУНД ХУГАЦААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

### Нэг. ТАНИЛЦУУЛГА

Монгол Улс НҮБ–ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит түгээмэл хэлэлцүүлэгт 2 дахь удаагаа орж, 2015 оны 5 дугаар сарын 5–ны өдөр НҮБ–ын Хүний эрхийн зөвлөлийн Нэгдсэн чуулганы үеэр 150 зөвлөмжийг хэрэгжүүлэхээр үүрэг амлалт авсан билээ.

Эхний хэлэлцүүлгийн дараа зөвлөмжийн орчуулга дээр төр болон төрийн бус байгууллагын хооронд байр суурь зөрүүтэй байсан нь хэрэгжилтийн шатанд хүндрэл үүсч байсан учраас хоёр дахь хэлэлцүүлгийн дараа зөвлөмжийн орчуулгыг нэгтгэх тухай зөвлөлдсөний дагуу Гадаад харилцааны яам орчуулгыг хийж, иргэний нийгмийн байгууллагатай зөвшилцсөний дүнд эцэслэсэн.

Үүний дараа зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулах шатанд мөн иргэний нийгэмтэй зөвшилцөж, төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газар 2016 оны 4 дүгээр сарын 11–ний өдрийн 204 дүгээр тогтоолоор баталсан. Уг төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг Ерөнхий сайдын 2016 оны 112 дугаар захирамжаар Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ахлуулан байгуулсан. Зөвлөлийн гишүүдээр 11 яамны Төрийн нарийн бичгийн дарга нар, 4 агентлагийн дарга, 8 иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, нарийн бичгийн даргаар Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын дарга болон Хууль зүй, дотоод хэргийн яамны Гэрээ, эрх зүй, хамтын ажиллагааны газрын дарга нар ажиллаж байна. Тус зөвлөлийн үндсэн үүрэг бол ерөнхий төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллахын зэрэгцээ явцын дүнг жил бүрийн эхэнд ээлжит хуралдаанаар хэлэлцэж, цаашид авах шаардлагатай арга хэмжээний саналыг биелэлтийн тайлангийн хамт Засгийн газрын хуралдаанд танилцуулахад оршиж байгаа. Орон тооны бус зөвлөл анхны хурлаа 2017 оны 1 дүгээр сард хийж хэрэгжилтэд явцыг сайжруулах зорилгоор яамдын дэргэд дэд зөвлөл байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд одоогоор яамдын дэргэд дэд зөвлөл байгуулагдан ажиллаж байна. Мөн Орон тооны бус зөвлөлийн ээлжит хурлыг 2018 оны 3 дугаар сарын 1–ний өдөр зохион байгуулсан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээд байна.

### Хоёр. АРГА ЗҮЙ

Зөвлөмжийн хэрэгжилтийн дунд хугацааны тайлан бэлтгэх хүрээнд Хүний эрхийн Төрийн бус байгууллагуудын форумтай зөвлөлдөх уулзалтыг 2018 оны 2 дугаар

сарын 2–ны өдөр зохион байгуулсан бөгөөд энэ уулзалтад Хүний эрхийн Үндэсний Комисс оролцсон юм.

Засгийн газрын зүгээс Хүний эрхийн төрийн бус байгууллагуудын форум болон Хүний эрхийн үндэсний комисстой хамтран бүсчилсэн хэлэлцүүлгийг баруун, зүүн, төв, говийн бүсийн 4 аймагт зохион байгуулсан болно. Эдгээр хэлэлцүүлэгт орон нутгийн төр, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллүүд оролцсон бөгөөд Засгийн газар, Хүний эрхийн форум тус бүрээс зөвлөмжийн хэрэгжилтийн явцын мэдээллийг танилцуулж хэлэлцүүлгийг өрнүүлсэн. Түүнчлэн Засгийн газраас Хүний эрхийн төрийн бус байгууллагуудын форум, Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран НҮБ–ын Хүний эрхийн зөвлөлөөс өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилтийн дунд хугацааны тайлангийн хэлэлцэх зөвлөлдөх уулзалтыг 2018–ны 5 дугаар сарын 17–ны өдөр Улаанбаатар хотод зохион байгууллаа.

### UPR Зөвлөмжийн хэрэгжилтийн байдал

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
108.2.	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколоор хүлээсэн үүргээ биелүүлэхэд чиглэсэн шаардлагатай бүх арга хэмжээг авах /Намиби/	Хэрэгжсэн. 2015 онд батлагдсан Эрүүгийн шинэчилсэн хуульд цаазаар авах ялыг ялын төрлөөс хасч хуульчилсан. Энэ хууль 2017 оны 7 дугаар сарын 1–ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.
108.3.	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколд нийцүүлэн үндэсний хууль тогтоомжоос цаазаар авах ялыг аль болох хугацаанд халах /Португал/	108.2–ыг үзнэ үү.
108.7.	Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколд нийцүүлэн зохих чадамж, нөөц бололцоотой үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагыг байгуулах /Чех/	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/66 дугаар тушаалаар ХЭҮК–ын тухай хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг байгуулсан. Энэ хуулийн төсөлд зохих чадамж, нөөц бололцоотой үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагыг тусгахаар ажиллаж байна.

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	108.8. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн Мэдээлэл хүргүүлж, хэлэлцүүлэх журмын тухай нэмэлт протоколыг соёрхон батлах /Монтенегро/	Хэрэгжсэн. Монгол Улсын УИХ уг протоколыг 2015 оны 4 дүгээр сарын 16–ны өдөр соёрхон баталсан.
	108.17. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэмд үндэсний хууль тогтоомжоо бүрэн нийцүүлэх, Олон улсын эрүүгийн шүүхийн Эрх ямба, дархан эрхийн тухай хэлэлцээрийг соёрхон батлах /Эстони/	Түрэмгийлэх асуудлаар Ромын дүрэмд орсон Кампала–гийн нэмэлт өөрчлөлтөд нэгдэн орох болон Олон улсын эрүүгийн шүүхийн Эрх ямба, дархан эрхийн тухай хэлэлцээрийг соёрхон батлах асуудлыг энэ оны намрын чуулганд өргөн барихаар тус тус ажиллаж байна.
	108.18. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрмийн зохицуулалтыг үндэсний хууль тогтоомждоо тусгах /Португал/	Шинэ Эрүүгийн хуулийн 29 дүгээр бүлэг буюу Хүн төрөлхтөний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг гэсэн бүлэгт түрэмгий дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх, төрлөөр устгах зэрэг Ромын дүрэмд хамаарах зохицуулалтыг тусгасан.
	108.19. Яс үндэс, шашин, бэлгийн чиг баримжаа, эсхүл хүйсийн баримжаа, илэрхийлэл, хэл, улс төрийн үзэл бодол, оюуны эсхүл биеийн хөгжлийн бэрхшээлийн улмаас ялгаварлан гадуурхагдах бүх хэлбэрээс зайлсхийх зорилгоор ялгаварлан гадуурхахын эсрэг цогц хууль тогтоомжийг батлах /Чили/	<ul style="list-style-type: none"> <li>– Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Хүүхдийн эрхийн тухай, Ахмад настны тухай, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай зэрэг хуульд ялгаварлан гадуурхахыг хориглосон байдаг. Тухайлбал, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрх” 2 дугаар бүлгийн 6 дугаар зүйлд Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг үл ялгаварлан гадуурхахыг хориглосон заалтуудыг оруулсан. Түүнчлэн</li> <li>– Хүн бүр хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байж, үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэн, нийгмийн баялгаас адил хүртэх эрхтэй. Хүнийг хөгжлийн бэрхшээл болон эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхахыг хориглоно.</li> <li>– Хөгжлийн бэрхшээлтэй хүний таатай, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, улс төрийн эрхээ эдлэхэд саад учруулахыг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ.</li> </ul>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
		<p>– Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх эрхээ эдлэхэд энэ хуульд зааснаас гадна иргэн, хуулийн этгээдийн дараахь үйлдэл, эс үйлдэхгүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ гэж хуульчилсан.</p> <p>Бид цаашид хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжид хөгжлийн бэрхшээл, хүйс, нийгмийн байдал болон бусад хүчин зүйлийн улмаас хүнийг ялгаварлан гадуурхсан заалт байгаа эсэхэд үнэлгээ хийж, шаардлагатай бол хуульд өөрчлөлт оруулах арга хэмжээ авна.</p> <p>“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Энэхүү нэмэлт өөрчлөлтөөр бусад хууль тогтоомж, бодлого хөтөлбөртэй уялдуулах, салбар дундын зохицуулалтыг сайжруулах, зарим арга хэмжээний эх үүсвэрийг тодорхой болгох, орхигдуулсан, салаа утгатай, тодорхой бус зүйл заалтыг засан сайжруулах, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг нэмж оруулах зэрэг асуудлыг шийдвэрлэх юм.</p> <p>Мөн шинэ Эрүүгийн хуулийн 14 дүгээр бүлгийн 14.1 дүгээр зүйл. “Ялгаварлан гадуурхах” –д эрүүгийн хэрэгт тооцохоор хуульчилсан. Түүнчлэн эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд боловсруулж батлуулсан хуулиудад ялгаварлан гадуурхах болохгүй гэдгийг тусгай зарчим болгон тусгасан. Хэрэв хууль зөрчиж ялгаварласан тохиолдолд гомдол хүсэлтээ гаргах, шийдвэрлүүлэх нөхцөл боломж хуульчлагдсан. Энэ хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор хууль сахиулах байгууллагын албан хаагчдад зориулсан эхний сургалтыг ЛГБТ ТББ-тай хамтран 2018–05 сард зохион байгууллаа.</p> <p>Хууль зүйн үндэсний хүрээлэнгээр “Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж дахь ялгаварлан гадуурхахын эсрэг зохицуулалтын хэрэгжилт: Бэлгийн цөөнхөд холбогдох зохицуулалт” сэдвийн хүрээнд судалгаа хийлгээд байна.</p>

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

<b>№</b>	<b>Зөвлөмж</b>	<b>Хэрэгжилтийн явц</b>
	108.20. Ялгаварлан гадуурхахтай тэмцэх цогц хууль тогтоомжийг батлах, ийнхүү батлах хууль тогтоомж, эсхүл одоо байгаа хуулиар тогтоосон тэгш байдлыг бодит амьдралд баталгаажуулах алхмыг авч хэрэгжүүлэх /Ирланд/	108.19–ийг үзнэ үү. Мөн боловсролд бүх төрлийн ялгаварлан гадуурхалаас урьдчилан сэргийлэх, ялангуяа цахим орчинд аливаа төрлийн ялгаваралд суралцагчдыг өртүүлэхгүй байх, сурагчдын бусдыг ойлгох чадварыг хөгжүүлэх, дэмжих зорилгоор хүүхдийн оролцоонд тулгуурлан цахим орчин дахь хүүхэд хамгааллын үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулж байна.
	108.21. ЛГБТ хүмүүс зэрэг нийгмийн цөөнх бүлгүүдийн нийт гишүүний эрхийг хамгаалах ялгаварлан гадуурхахын эсрэг иж бүрэн хууль тогтоомжийг батлах / Англи/	108.19–ийг үзнэ үү.
	108.22. Эрүүгийн шинэ хуулиа батлах явцаа хурдасгаж /Турк/	Эрүүгийн шинэ хууль 2017 оны 7 дугаар сарын 1–ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.
	108.23. Хүн бүрийн эрх тэгш болон аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин, хүний эрхийн соёлыг баталгаажуулахын тулд Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулах, бусад шаардлагатай эрх зүйн орчноо сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй нааштай ажлаа хурдасгаж, батлагдсан хуулиа үр дүнтэй хэрэгжүүлэх /Норвеги/	Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Прокурорын тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг 2017 оны 06 дугаар сарын 09–ний өдрийн УИХ–ын чуулганы нэгдсэн хуралдаанаар тус тус хэлэлцэн баталж, мөн оны 07 дугаар сарын 01–ний өдрөөс дагаж мөрдөхөөр тогтсон. Дээрх хуулиудын хэрэгжилтийг хангах бэлтгэл ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдын санаачлагаар “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2017 оны 05 дугаар сарын 26–ны өдрийн 28, А/49, А–141 захирамж/тушаал гаргаж, холбогдох арга хэмжээг богино хугацаанд авч хэрэгжүүлсэн. Тухайлбал, төрийн захиргааны болон хуулийн байгууллагын нийт 180 албан тушаалтныг хамруулсан 5 өдрийн сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулснаас гадна бэлтгэгдсэн сургагч багш нарыг тус бүрт 9–10 багшийн бүрэлдэхүүнтэй багуудад хуваан, нийслэлийн 9 бүс, орон нутгийн 11 бүсэд 2017 оны 06 дугаар

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
		<p>сарын 11–24–ний өдрүүдэд бүс тус бүрт нийт 5 өдрийн сургалт зохион байгуулж, шинэчлэн батлагдсан хуулиудын үзэл баримтлалыг таниулж мэдлэг олгох уг сургалтанд нийт 8191 албан хаагч, ажилчдыг хамруулсан. Түүнчлэн сургагч багш нарт болон хуулиудыг хэрэгжүүлэх албан хаагч, сургалтанд оролцогчдод зориулан шинэчлэн батлагдсан хуулиудын талаар тус бүр нь 600–700 орчим хуудас бүхий 2 боть гарын авлагыг бэлтгэх ажлыг зохион байгуулж, сургалтанд хамрагдсан нийт албан хаагчдад ажлын хэрэгцээнд зориулан тараасан.</p>
	<p>108.24. Хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настай хүмүүс, эмэгтэйчүүд зэрэг хүн амын эмзэг бүлгийн эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих ажлаа үргэлжлүүлэх /ОХУ/</p>	<p>– Монгол Улс сүүлийн гурван жилийн хугацаанд, гэр бүлийн чиглэлээр хууль эрх зүйн орчныг шинэчлэх, энэ чиглэлээр хэрэгжүүлэх бодлого тодорхойлох, хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээнд шаардагдах хөрөнгийг шийдвэрлэхэд ихээхэн ахиц дэвшил гарсан.</p> <p>– Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд нөхцөл байдлын үнэлгээ хийх, хүүхдийн асуудлаарх мэдээллийн сан бий болгох, хүүхдийн эрхийн улсын байцаагч, нийгмийн ажилтны ёс зүй, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэгчдийг магадлан итгэмжлэхтэй холбоотой 10 дүрэм, журам, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд хохирогчид үзүүлэх түр хамгаалан байрлуулах, нийгмийн халамжийн, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх болон сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, холбон зуучлах ажлыг зохион байгуулах асуудлын зохицуулалтыг тусгасан нийт 12 дүрэм, журмыг баталж, хэрэгжүүлж байна.</p> <p>– Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийг (2017–2021 он) Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 20–ны өдрийн 270 дугаар тогтоолоор, хөтөлбөрийг 2018–2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг ХНХ–ын,</p>

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
		<p>БСШУС–ын, ЭМ–ын сайдын хамтарсан тушаалаар батлан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд бүх яам, агентлаг, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайдаар ахлуулсан “Хүүхдийн хөгжил, хамгааллын байнгын ажлын хэсэг” – байгуулагдан ажиллаж байна.</p>
	<p>108.24. Хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настай хүмүүс, эмэгтэйчүүд зэрэг хүн амын эмзэг бүлгийн эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих ажлаа үргэлжлүүлэх /ОХУ/</p>	<p>– Монгол Улсын Ерөнхий сайдын тэргүүлдэг Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн хурлыг 2018 оны 5 дугаар сарын 18–ны өдөр зохион байгуулж, хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, УИХ–ын Хууль зүйн байнгын хорооны 2018 оны 02 тоот тогтоолын хэрэгжүүлэх талаар холбогдох яам, агентлагуудад үүрэг, чиглэлийг Ерөнхий сайдаас өгөв. Мөн Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны төлөвлөгөөг батлуулан, Үндэсний зөвлөлийн тогтоол, хурлын тэмдэглэлийг гишүүд болон орон нутгийн хүүхдийн зөвлөлийн тэргүүн нарт хэрэгжилтийг хангуулахаар хүргүүлээд байна.</p> <p>– Засгийн газрын 2016 оны 55 дугаар тогтоолоор Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэд “Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв”–ийг байгуулсан ба уг төвд сард дунджаар 10 мянга гаруй дуудлага, хандалт ирж байна. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/292 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу тус төвийн тээврийн хэрэгсэлд тусгай болон гэрлэн дохио хэрэглэж байгаа нь хүүхдэд хүүхэд хамгааллын яаралтай тусламж, үйлчилгээг үзүүлэх боломжийг нэмэгдүүлсэн.</p> <p>Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв 2017 онд <b>144,869</b> дуудлага хүлээн авч, 3173 тохиолдлыг аймаг, орон нутгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс /ГБХЗХХ/, Хамтарсан багт шилжүүлснээс 63%–ийг шийдвэрлэсэн байна. 2018 оны хагас жилийн байдлаар <b>84,819</b> дуудлага хүлээн авч <b>2569 тохиолдлыг</b> аймаг, дүүргийн ГБХЗХГ–ын хүүхэд хамгааллын мэргэжилтэн, хамтарсан багт холбон зуучилж, <b>936 тохиолдлыг</b> шийдвэрлэж, нийгмийн үйлчилгээ үзүүлсэн.</p>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
		<p>Мөн <b>327</b> хүүхдийг шуурхай дуудлагаар хүлээн авч Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байранд аюулгүй байдлын хамгаалалтын үйчилгээ үзүүлсэн байна.</p>
	<p>108.24. Хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настай хүмүүс, эмэгтэйчүүд зэрэг хүн амын эмзэг бүлгийн эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих ажлаа үргэлжлүүлэх /ОХУ/</p>	<p>–Үндэсний хэмжээнд 12 аймаг, нийслэлийн Хан–уул дүүрэг, Баянгол дүүрэгт түр хамгаалах байр ажиллаж, 2018 оны 5 дугаар сарын 31–ний байдлаар түр хамгаалах байранд 629 хүүхдийг хүлээн авч, үйлчилсэн байна. Үүнээс Засгийн газрын 2017 оны 231 дүгээр тогтоолоор байгуулагдсан Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх “Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр 0–18 хүртэлх насны <b>423</b> хүүхдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн байна.</p> <p>– Нийслэлийн Цагдаагийн газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газраас эцэг эхийн хараа хяналт сул хүүхдийг илрүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулж, хүүхдүүдийг эцэг эх асран хамгаалагчид нь хүлээлгэн өгөх, шаардлагатай тохиолдолд хамгаалах байр, халамж, асрамжийн төвүүдэд байршуулж, удаан хугацаагаар тэнэсэн гэр бүлдээ очих боломжгүй хүүхдүүдийг Багахангай дүүрэгт байгуулсан “Хараа хяналтгүй хүүхдийг нийгэмшүүлэх төв”–д байрлуулан нийгэм, сэтгэлзүйн нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлж байна. Одоогоор тус төвд 17 хүүхдэд үйлчилгээ үзүүлж байна.</p> <p>Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудлаар судалгаа, шинжилгээ хийх, салбарын хүний нөөцийг чадавхжуулах чиг үүрэгтэй “Сургалт, судалгаа, мэдээллийн төв”–ийг байгуулан төрийн бүх шатны байгууллага, эцэг эхчүүд, олон нийтэд чиглэсэн хүүхдийн эрх, хамгаалал, хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн боловсрол олгох сургалт “Хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлье” аян, “Эцэг эхийн зөвлөгөөн” зэрэг олон нийтэд чиглэсэн арга хэмжээг үндэсний хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна.</p>



№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
		<p>–Хүүхдийн эрх, хамгааллын болон гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид хуульд заасан үйлчилгээг үзүүлэх үүрэг бүхий ажилтнуудын чадавхийг дээшлүүлэх хууль, тогтоомжийг олон нийтэд таниулан сурталчлах, ойлголт хандлагыг нэмэгдүүлэх ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Тухайлбал:</p> <p>– Хүүхдийн эрхийн хэрэгжилтэд хяналт тавих, Зөрчлийн тухай хуульд заасан хүүхдийн эсрэг 16 төрлийн зөрчлийг шалган шийдвэрлэх чиг үүрэгтэй ажиллах хүүхдийн эрхийн байцаагчийг Хүүхдийн эрхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэгт заасны дагуу сонгон шалгаруулж, сургалтанд хамруулан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/181 тоот тушаалаар 32 албан хаагчид Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрх олгосон. 2017 онд 26, 2018 оны эхний хагас жилд 87 зөрчлийг илрүүлсэнээс шийдвэрлэсэн хэргийн тоо– 55, шалгаж буй хэрэг –19, Шийтгэл, ноогдуулсан хэргийн тоо–13 /1.950,000/ төгрөгний торгууль оногдуулсан байна. Хүүхдийн эрхийн улсын байцаагч нарын 2018 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/84 тоот тушаалаар батлан “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”–ын дагуу хяналт шалгалт хийх, дотуур байр, сүм хийд, дотуур байр, интернэт тоглоомын газруудад төлөвлөгөөт хяналт, шалгалт хийж, зөвлөн туслах, зөрчлийг илрүүлэх, шалгах, хууль сурталчлах үйл ажиллагаа зохион байгуулан, ажиллаж байна.</p> <p>– Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар эрсдэлт нөхцөлд амьдарч хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй 609 Хамтарсан баг ажиллаж байна. 2017 онд Хамтарсан багийн гишүүдийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамтарсан багийн 4600 гаруй</p>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
		<p>гишүүдийг хамруулсан бөгөөд давтан сургах сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулж байна. Хамтарсан багаас 2017 онд 1298, 2018 оны 2 дугаар улирлын байдлаар 1548 гэр бүлийн хүчирхийлэлтэй гэр бүлтэй ажиллаж, 2336 хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж, давхардсан тоогоор 6318 хүүхэд, иргэнд аюулгүй байдлын хамгаалалт, сэтгэл зүйн зөвлөгөө, эмнэлгийн тусламж, холбон зуучлах үйлчилгээг үзүүлсэн байна.</p> <p>–ХНХ–ын, ХЗДХ–ийн сайдын 2017 оны А/51, А/69 тоот хамтарсан тушаалаар баталсан журмын дагуу аймаг, дүүрэгт хууль зөрчсөн, гэмт хэргийн гэрч, хохирогч болсон хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх чиг үүрэгтэй салбар дундын “Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо” байгуулагдан ажиллаж, 2017 онд 618 хүүхдэд, 2018 оны 2 дугаар улирлын байдлаар 897 хүүхдэд эрх зүйн туслалцаа, зөвлөгөө, үйлчилгээ үзүүлсэн байна.</p> <p>–Хүүхэд хамгааллын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний стандарт”–ыг 2017 оны 12 дугаар сард Стандартчиллын үндэсний зөвлөлөөр батлуулсан. Шинэчлэгдсэн стандартыг халамж, асрамжийн төвүүдэд мөрдүүлэх ажлыг зохион байгуулж байна.</p> <p>–Нийслэлийн хороодын Хэсгийн ахлагч нарын ажил үүргийн хуваарьт хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийг мэдээлэх, урьдчилан сэргийлэх чиг үүргийг оруулж, бүх Хэсгийн ахлагч нарыг сургалтад хамруулах ажлыг үе шаттай зохион байгуулж байна.</p> <p>Улс орон эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлыг даван туулж байгаа хэдий ч хүүхэд, гэр бүлийн нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч, дараах хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Үүнд:</p> <p>–Хүн амын өсөлтийг дэмжих, хүүхдээ гэртээ асарч байгаа ээжүүдийн орлогын баталгааг хангах, олон хүүхэдтэй өрхийг дэмжих зорилгоор “Цалинтай ээж” хөтөлбөрийн хүрээнд 0–3 хүртэлх насны</p>

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
		<p>хүүхэдтэй эхчүүдэд сар бүр 50.0 мянган төгрөгийн тэтгэмж олгох Засгийн газрын тогтоол гаргалаа. 2018 оны эхний улирлын байдлаар тус хөтөлбөрт 152.8 мянган эхчүүд хамрагдаад байна.</p> <p>– Түүнчлэн хүүхдийн хөгжлийг дэмжих зорилгоор Засгийн газрын 2016–2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хүүхдийн мөнгийг хүүхэд бүрд олгоно гэсэн зорилт туссаны дагуу 2017 оны гүйцэтгэлээр Өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн өрхийн 0–18 хүртэлх насны 1.0 сая 34.0 мянган хүүхдэд сар бүр 20.0 мянган төгрөгийг олгоход улсын төсвөөс 257.6 тэрбум төгрөгийг зарцуулсан. Эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлд зорилтот өрхийн нийгмийн хамгааллын зардлыг бууруулахгүй байх үүднээс хүүхдийн мөнгийг нийт хүүхдийн 60 хувьд нь буюу 684.0 мянган хүүхдэд бэлэн мөнгөөр олгож байсныг, Засгийн газраас 2018 оны 2 дугаар улирлаас хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хамрах хүрээг нэмэгдүүлэх шийдвэрийг гаргаж, Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна.</p> <p>– Ядуу, эмзэг бүлэгт хүрдэг хүнсний эрхийн бичгийн хамрах хүрээг 2017 оны 11 дүгээр сараас 2 дахин, мөнгөн дүнгийн хэмжээг 20 хувиар буюу сард том хүн 13000 төгрөг байсныг 16000 төгрөг, хүүхэд 6500 төгрөг байсныг 8000 төгрөг болгон нэмэгдүүлж 52,3 мянган өрхийн 285,3 мянган иргэнийг хамруулахаар болсон. Үүнтэй холбоотойгоор Хүнсний эрхийн бичиг олгох журамд өөрчлөлт оруулж, өрхийн зарим гишүүнийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах нөхцөл шалгуур тавьж, биелүүлсэн тохиолдолд хүнсний эрхийн бичгийг үргэлжлүүлэн олгохоор зохицууллаа.</p> <p>– Нийгмийн халамжийн тэтгэвэрийг 140.000 /нэг зуун дөчин мянга/-аас 155.000 /нэг зуун таван мянга/ төгрөг, асаргааны тэтгэмжийг 64.000 /жаран дөрвөн мянга/-аас 70.000 /далан мянга/ төгрөг болгон нэмүүллээ.</p> <p>– Протез, ортопед, тусгай хэрэгслийн нэр төрөл, жишиг үнийг өөрчлөхөөр ажиллаж байна.</p>

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	108.25. Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг өөрчлөн Парисын зарчимд нийцүүлэн өөрчилж, комиссын чадавхыг сайжруулах /Сиерра Леон/	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/66 дугаар тушаалаар ХЭҮК-ын тухай хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсэг байгуулан шаардлагатай судалгааг хийж байна.
	108.26. Боловсролын салбарт, ялангуяа хууль сахиулах алба хаагчдад хүний эрхийн сургалт хийх хүчин чармайлтаа үргэлжлүүлэх /Морокко/	Хууль сахиулах байгууллага ялангуяа цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, хилийн цэрэг, гадаадын иргэн харьяатын албаны алба хаагчдын сургалтын хөтөлбөрт Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн чиглэлийн олон улсын гэрээнүүдийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэхээр хүний эрхийн сэдвийг тусган сургалтыг зохион байгуулж байна. Гадаад харилцааны яамнаас UPR Trust Fund-ын төслийн хүрээнд “Хүний эрхийн олон улсын гэрээний тайлан гаргах, хэрэгжүүлэх үндэсний чадавхийг бэхжүүлэх зорилгоор ХЭҮК-ын <b>e-learning platform</b> -ыг боловсронгуй болгох, төрийн байгууллагын албан хаагчдад зориулж холбогдох сургалт зохион байгуулах” –аар ажиллаж байна
	108.27. Шүүгч, магистратуудын байнгын болон заавал хамрагдах сургалтын хөтөлбөрт хүний эрхийн болон олон улсын гэрээг хэрэглэх сургалтыг оруулах /Мексик/	Хүний эрхийн чиглэлийн олон улсын конвенцийн практик хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор Хуульчдын холбоотой хамтран ажиллаж байна.
	108.28. Хүний эрхийн Үндэсний Комиссын хараат бус байдлыг Парисын зарчимд нийцүүлэн түүний бүрэн эрхийг бэхжүүлэх /Чили/	108.25-ыг үзнэ үү.
	108.29. Хүний эрхийн Үндэсний Комиссын хараат бус байдлыг баталгаажуулахын тулд илүүтэй дэмжлэг үзүүлэх /Австрали/	108.25-ыг үзнэ үү.

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

<b>№</b>	<b>Зөвлөмж</b>	<b>Хэрэгжилтийн явц</b>
108.30.	Хүний эрхийн чиглэлээрх үндэсний байгууллагууд болон тогтолцоогоо бэхжүүлэх ажлаа үргэлжлүүлэх /Непал/	Хүний эрхийн үндэсний комисс үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байгаа бөгөөд түүний үйл ажиллагааг бэхжүүлэх зорилгоор хуулийг нь шинэчлэхээр ажиллаж байна. Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх Ажлын хэсгийг 2017 онд шинэчлэн байгуулсан бөгөөд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж байна. Төрийн бус байгууллагын тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд хуулийн төслийн эхний хувилбар болон үзэл баримтлалын төслийг боловсруулж, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулж, хэлэлцүүлэг зохион байгуулж, саналыг аваад байна.
108.31.	Парисын зарчмын дагуу бүрэн эрхээ чөлөөтэй, хараат бусаар хэрэгжүүлдэг болгох зорилгоор Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын чадавхийг өргөжүүлэн бэхжүүлэх шаардлагатай арга хэмжээг авах /Намиби/	108.25–ыг үзнэ үү.
108.32.	Парисын зарчимд нийцүүлэх зорилгоор Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагааг сайжруулах, ялгаварлан гадуурхалтын эсрэг үр нөлөөтэй тэмцэх эрх зүйн орчныг нь бэхжүүлэх /Нигер/	108.25–ыг үзнэ үү.
108.33.	Монгол Улсад хүний эрхийг үр нөлөөтэй эдлүүлэх зорилгоор хүний эрхийн байгууллагуудыг бэхжүүлэх хүчин чармайлтаа цаашид үргэлжлүүлэх /Пакистан/	108.30–ыг үзнэ үү.

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.34. Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн зэрэг хамгийн эмзэг бүлгийн иргэдийн эрхийг хамгаалах үндэсний хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэх үүрэг амлалтаа биелүүлэх /Румын/</p>	<p>Энэ салбарын бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дүнд үндэслэн Өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр /2016–2020/, Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр зэргийг шинэчлэн боловсруулж ЗГ–ын тогтоолоор батлуулсан. Холбогдох хууль, хөтөлбөрт заасан салбар хоорондын уялдаа зохицуулалтыг сайжруулах, үндэсний тогтолцоог бэхжүүлэх хүрээнд Жендерийн үндэсний хороо, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөл зэрэг хороо, зөвлөлийг байгуулан ажиллуулж байна. Эдгээр бүрэлдэхүүнд хөдөлмөр, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсрол, хүнс, хөдөө аж ахуй, санхүү, эдийн засаг зэрэг бүхий л холбогдох салбарын төлөөлөл багтаж байгаа бөгөөд дээрх бодлого хөтөлбөрийг салбар, байгууллагын үйл ажиллагаатай уялдуулах, төлөвлөлтөндөө тусган хэрэгжүүлэх чиг үүргийг хүлээн ажиллаж байна.</p>
	<p>108.35. Засгийн газрын чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагуудыг оролцуулан бүх түвшинд хүний эрхийн боловсрол олгох, сургах хүчин чармайлтаа үргэлжлүүлэх /Пакистан/</p>	<p>Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор Бүх нийтийн эрх зүйн боловсрол олгох үндэсний хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж байна.</p>
	<p>108.36. Ээлжит нэгдсэн хэлэлцүүлгийн зөвлөмжийг оролцуулан олон улсын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах тогтолцоог бий болгох боломжийг судлан үзэх /Парагвай/</p>	<p>Ээлжит нэгдсэн хэлэлцүүлгийн зөвлөмж болон хүний эрхийн гэрээний байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх тогтолцоо, механизм бий болгох тодорхой алхам хийж байна. Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын 2 дугаар ээлжит тайланг хэлэлцүүлж НҮБ–ын Хүний эрхийн зөвлөлөөс өгсөн зөвлөмжийг 2016–2019 онд хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоолоор баталсан. Мөн Ерөнхий сайдын 2016 оны 112 дугаар захирамжаар дээрх төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий Орон тооны бус зөвлөлийг Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ахлуулж, бүх яамны Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулан байгуулсан.</p>

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

<b>№</b>	<b>Зөвлөмж</b>	<b>Хэрэгжилтийн явц</b>
	<p>108.36. Ээлжит нэгдсэн хэлэлцүүлгийн зөвлөмжийг оролцуулан олон улсын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах тогтолцоог бий болгох боломжийг судлан үзэх /Парагвай/</p>	<p>Төлөвлөгөөний дунд хугацааны хэрэгжилтийн тайланг ХЗДХЯ, ГХЯ, ХЭҮК, Хүний эрхийн төрийн бус байгууллагуудын сүлжээ хамтран орон нутагт бүсчилсэн байдлаар хэлэлцүүлснээс гадна, нэгдсэн байдлаар төр, төрийн бус байгууллагууд хоёр удаа хэлэлцүүлэг зохион байгуулсан нь дунд хугацааны хэрэгжилтийн тайланг бодитой гаргах, төр, төрийн бус байгууллагууд хамтран ажиллах дадал, соёлыг бэхжүүлэх, цаашилбал Монгол Улсад хүний эрхийг хамгаалах, хэрэгжүүлэхэд ач холбогдолтой ажил болсон гэж дүгнэж байна.</p> <p>Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийн талаарх 8, 9 дүгээр нэгтгэсэн тайланг хэлэлцүүлж, гэрээний хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх салбар дундын ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайдын 2016 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/241 тоот тушаалаар байгуулан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлж байна. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 20-ны 270 дугаар тогтоолоор “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийг баталж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх Хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын салбар дундын ажлын хэсгийг холбогдох яам, агентлаг, төрийн бус байгууллагын оролцоотой байгуулж ажиллаж байна. Энэ хөтөлбөрийн зорилго нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх үндэсний 5 дугаар тайланг хэлэлцүүлсэнтэй холбогдуулан Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн зөвлөмж, мөн Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль болон бусад хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэж байна.</p>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.37. Хүний эрхийн салбар дахь олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр ажиллах /Туркменистан/</p>	<p>Монгол Улс НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганаар “Хөдөөгийн охид, эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах тухай”, “Бичиг үсгийн боловсролын тухай” мөн “Ардчиллын боловсролын тухай” тогтоолыг санаачилж, хоёр жил тутамд батлуулж ирсэн нь эмэгтэйчүүдийн эрх, сурч боловсрох эрх болон сайн засаглалыг бэхжүүлэх үйл хэргийг урагшлуулахад тодорхой хувь нэмэр болж байгаа гэж үзэж байна. Түүнчлэн Монгол Улс цаазаар авах ялыг халахад чиглэсэн олон улсын хамтын нийгэмлэгийн хүч чармайлтыг дэмжиж, хувь нэмрээ оруулахыг эрмэлзэж ирлээ. Монгол Улс Цаазын ялын эсрэг Олон улсын Хороог Дэмжих бүлгийн гишүүнээр идэвхтэй ажиллаж байгаагаас гадна Европын Холбоо, Аргентиний талтай хамтран “Цаазаар авах болон эрүүдэн шүүхэд ашигладаг бүтээгдэхүүний худалдааг хориглох Дэлхий нийтийн холбоо” санаачилгыг эхлүүлэв. Санаачилгын нээлтийн арга хэмжээ 2017 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр НҮБ-ын төв байранд болж Монгол Улсын Гадаад харилцааны сайд оролцсон. Түүнчлэн Монгол Улс 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдөр НҮБ-ын төв байранд Цаазаар авах ялын эсрэг дэлхийн өдрийг тэмдэглэх арга хэмжээг ХЭДКА-тай хамтран зохион байгуулсан болно.</p>
	<p>108.38. 2003 онд хүргүүлэх байсан ч одоог хүртэл хүргүүлээгүй байгаа анхдугаар илтгэлээ НҮБ-ын Эрүү шүүлтийн эсрэг хороонд хүргүүлж, хороотой үр нөлөөтэй хэлэлцүүлэг эхлүүлэх бололцоог олгох /Дани/</p>	<p>Монгол Улсын Засгийн газар анхны тайлангаа 2009 онд хүргүүлж, холбогдох Хороогоор 2010 онд хэлэлцүүлсэн.</p>



**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

<b>№</b>	<b>Зөвлөмж</b>	<b>Хэрэгжилтийн явц</b>
	<p>108.39. Хүний эрхийн зөвлөлийн Тусгай процедур болон гэрээний байгууллагууд зэрэг олон улсын хүний эрхийн хяналтын механизмуудтай ажиллах цаашдын хамтын ажиллагааг судлан үзэх /Туркменистан/</p>	<p>Монгол Улс Хүний эрхийн зөвлөлийн олон улсын гэрээний хэрэгжилтийг хангах механизмын үйл ажиллагааг бүх талаар дэмжиж хамтран ажиллахын төлөө байдаг бөгөөд 2004 онд Хүний эрхийн зөвлөлийн бүтцэд багтдаг байгууллагын төлөөллийг Монгол Улсад тааламжтай үедээ айлчлах нээлттэй урилга хүргүүлсэн. НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг Дэд хороо (Subcommittee on Torture Prevention)-ны төлөөлөгчид 2017 оны 9 сарын 11–20-ны өдөр Монгол Улсад ажиллаж, конвенц болон түүний нэмэлт протоколын хэрэгжилтийн байдалтай танилцсан. Дэд хороо 9 дүгээр сарын 19-ний өдөр Засгийн газрын төлөөлөлтэй уулзаж, айлчлалынхаа дүнг урьдчилсан байдлаар танилцуулсан. Дэд хорооны төлөөлөгчид Монгол Улсад ажилласан тухай тайлан 2018 оны III дугаар улиралд эцэслэгдэнэ. Мөн НҮБ-ын Эрүүл, аюулгүй, цэвэр, тогтвортой орчинд амьдрах эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч ноён Жонн Кнокс 2017 оны 9 дүгээр сарын 19–27-ны өдөр Монгол Улсад айлчилсан бөгөөд айлчлалынхаа дүнг 2018 оны 03 дугаар сард болсон Хүний эрхийн зөвлөлийн 37 дугаар чуулганд танилцуулсан. Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах эрхийн асуудлаарх Тусгай илтгэгч Лео Хеллер 2018 оны 4 дүгээр сарын 9–20-ны өдөр Монгол Улсад айлчилсан. Тусгай илтгэгч айлчлалынхаа тайланг манай талд ирүүлээд байгаа бөгөөд 2018 оны 9 дүгээр сард болох ХЭЗ-ийн 39 дүгээр чуулганд танилцуулна.</p> <p>БНАСАУ дахь хүний эрхийн байдлын асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч ноён Томас Охеа Кинтана 2018 онд манай улсад айлчлах хүсэлтээ илэрхийлсэн бөгөөд хугацааг тохиролцох чиглэлээр ажиллаж байна.</p>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.40. Хүний эрхийн салбар дахь техникийн туслалцааны болон чадавхийг сайжруулах олон улсын хөтөлбөрүүдэд идэвхитэй оролцох /Туркменистан/</p>	<p>Монгол Улсын Хүний эрхийн төлөв байдлын хоёрдугаар тайланг хэлэлцүүлэн Хүний эрхийн хорооноос өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх техникийн туслалцааны төсөл хэрэгжүүлэхээр ХЭДКА-тай хамтран ажиллаж байна. Энэ төслийг хэрэгжүүлэх нь 1/ Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний механизм байгуулах, 2/ хүний эрхийн гэрээний тайлан бэлтгэх чадавхийг бэхжүүлэх, ХЭҮК-ийн e-plat-form-ийг боловсронгуй болгох, 3/ Хүний эрхийг хамгаалагчийн хуулийг сурталчлах, 4/ Бизнес, хүний эрхийн зарчмыг хэрэгжүүлэх үндэсний төлөвлөгөө гаргах болон 5/ ЛГБТ хүмүүсийн эрхийг хүндэтгэх, хамгаалах асуудлаар олон нийтийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой болох юм.</p> <p>Монгол Улс, ЕХ-ны хүний эрхийн диалогийг дэмжих төслийг ЕХ-той хамтран 2017 оны 10 дугаар сараас хэрэгжүүлж эхлээд байна. Төслийн хүрээнд хүний эрхийн асуудлаар цуврал 3 семинар зохион байгуулах бөгөөд өнгөрсөн хугацаанд “Эрүүгийн эрх зүйн тогтолцоон дахь хүний эрхийн хэрэгжилт” бага хурлыг 2018 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр, “Хүүхэд, өсвөр үеийн эсрэг хүчирхийлэл, нийгмийн шалтгаант нөхцөл, хамгаалал” сэдэвт бага хурлыг 6 дугаар сарын 6-ны өдөр тус тус зохион байгуулав. Энэ төслийн хүрээнд Эрүүгийн шинэчилсэн хууль, түүнтэй холбогдох бусад хуулийг хэрэгжүүлэх прокурорын байгууллагын чадавхийг бэхжүүлэх, мөн прокурорын Ерөнхий газрын Сургалт судалгааны төвд сургалт арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр ЕХ-той хамтран ажиллаж байна. Мөн Монгол Улсын нэгдсэн орсон хүний эрхийн олон улсын гэрээг орчуулах, хэвлэн нийтлэх ажлыг хэрэгжүүлж байна.</p>
	<p>108.41. Аливаа шалтгаанаар ялгаварлан гадуурхахтай тэмцэх шинэ хууль тогтоомжийг батлах /Уругвай/</p>	<p>108.19-ийг үзнэ үү.</p>

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

<b>№</b>	<b>Зөвлөмж</b>	<b>Хэрэгжилтийн явц</b>
	108.42. Ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийн эсрэг, түүний дотор хохирогчдын эрхийг хамгаалсан цогц хууль батлах /Чех/	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг 2013 онд батлан хэрэгжүүлж байна.
	108.43. Хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах чиглэлээрх арга хэмжээнүүдээ үргэлжлүүлэн хэрэгжүүлэх /Япон/	<p>Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяныг жил бүрийн 11 дүгээр сарын 25–ны өдрөөс 12 сарын 08–ны өдрийг хүртэл зохион байгуулахын зэрэгцээ Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах олон улсын өдрийг тэмдэглэхэд бүтээлч, бодит ажил, арга хэмжээг хэрэгжүүлж бодит байдлаар хандаж байна. Тухайлбал, оюутан залуучуудын дунд жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх илтгэл, эссе бичлэгийн уралдаан зарлах; Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Ерөнхий сайдын ажлын алба, Засгийн Газрын Хэрэг эрхлэх газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, салбарын яамд, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар зэрэг төрийн байгууллагуудын дунд хүчирхийллийн эсрэг байр сууриа илэрхийлж “Цагаан тууз” зүүх аян зохион байгуулах; жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, өртөх, мэдээлэх үед авах арга хэмжээний талаарх мэдээлэл, зөвлөгөөг алслагдсан захын дүүрэг хороодын иргэдэд явуулын байдлаар буюу автобустай үйлчилгээний хэлбэрээр хүргэх; жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх гадаадын болон дотоодын шилдэг медиа контентыг сургалт, нөлөөллийн арга хэмжээнд ашиглах, хөгжүүлэх зэргээр бодит үр дүнг чухалчлан ажиллаж байна.</p> <p>Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, таслан зогсоох, нөгөө талаар, эрэгтэйчүүдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй буруу зан үйл, хандлагыг засах, тэдэнд нөлөөлөх арга хэмжээг эрэгтэйчүүдийн төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэх замаар энэ үйл ажиллагаанд эрэгтэйчүүдийг татан оролцуулж байна.</p>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.43. Хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах чиглэлээрх арга хэмжээнүүдээ үргэлжлүүлэн хэрэгжүүлэх /Япон/</p>	<p>Энэ хүрээнд эрэгтэйчүүдэд нөлөөлөх нөлөөллийн сургалтыг Эрэгтэйчүүдийн хөгжлийн нийгэмлэг, Эрчүүд, гэр бүл хөгжлийн нийгэмлэг, Хөгжлийн төлөөх Монгол эрчүүд төрийн бус байгууллагатай хамтран 2018 оны эхний хагаст 4 удаа зохион байгуулж МУБИС–ийн багш нар, Улаанбаатар эрдэм их сургуулийн оюутнууд, Нийслэлийн Цагдаагийн газрын албан хаагчид, Эрэгтэйчүүдийн хөгжлийн нийгэмлэгийн идэвхтэн гишүүд нийт 200 гаруй эрэгтэйчүүдийг хамруулж, жендэрийн тэгш байдал, хүчирхийлэл, амьдралын эрүүл зөв зан үйлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүллээ. Түүнчлэн Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2017.10.31–ны өдрийн хамтарсан “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тушаалаар шинжилгээний байгууллагаас “Насанд хүрээгүй иргэнийг үзлэг шинжилгээнд үнэ төлбөргүй хамруулна.”, мөн амьдралын баталгаажих түвшингээс доогуур орлоготой, нэн ядуу иргэнийг “Яаралтай үзлэг шинжилгээ хийх шаардлагатай тохиолдолд энэ журмын 3.4–д заасан баримтыг шаардахгүй.” гэсэн нэмэлтийг оруулсны дагуу тухайн иргэд, өсвөр насныханд шүүхийн шинжилгээний байгууллагаас үзүүлж буй үзлэг, шинжилгээг үнэ төлбөргүй үзүүлж байна.</p> <p>Мөн 108.24–ийг үзнэ үү.</p>
	<p>108.44. Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн үүрэг, хариуцлагын талаарх нийгмийн хэвшмэл ойлголтыг өөрчлөх, ялгаварлан гадуурхах уламжлалт зан үйлийг халах арга хэмжээнийхээ үр нөлөөг сайжруулах хүчин чармайлтаа нэмэгдүүлэх /Словени/</p>	<p>Жендэрийн талаарх ойлголт, мэдээллийг нэмэгдүүлэх: –Жендэрийн тэгш байдлыг хангах бодлогын чиг хандлагыг хэлэлцэх, түншлэл хамтын ажиллагааг хөгжүүлэх, жендэрийн тэгш байдлын талаарх олон нийтийн ойлголт, мэдээллийг нэмэгдүүлэх, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, үндэсний хөтөлбөрийг сурталчлах үүднээс “Жендэр ба Хөгжил” үндэсний чуулганыг Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Жендэрийн үндэсний хорооноос санаачлан 2018 оны 02 дугаар сарын 01–ний өдөр Төрийн ордны Их танхимд зохион байгуулсан.</p>

ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
		<p>Үндэсний чуулганд Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, Хүний эрхийн үндэсний комисс, Төрийн албаны зөвлөл, яамд (Жендэрийн салбар зөвлөл), нийслэл, аймаг, дүүргийн Засаг дарга (Жендэрийн салбар хорооны дарга) болон төрийн холбогдох ажилтан, албан хаагчид, төрийн бус, иргэний нийгмийн байгууллага, эрдэм шинжилгээ, судалгаа, олон улсын байгууллагуудын 600 гаруй зочид, төлөөлөгчид оролцсон. Үндэсний чуулганы төлөөлөгчид Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Жендэрийн үндэсний хорооны орлогч дарга С.Чинзоригийн танилцуулсан “Төрөөс жендэрийн талаар баримтлах бодлого, үр дүн, зорилт” сэдэвт үндсэн илтгэлийг сонсож, төрийн болон төрийн бус, иргэний нийгмийн байгууллагын өрнүүлсэн нээлттэй хэлэлцүүлгийн үр дүнд жендэрийн тэгш байдлыг хангах бодлогын чиг хандлага, түншлэл, хамтын ажиллагааг эрчимжүүлэх нэгдсэн зөвшилцөлд хүрсэн. Чуулганаас гарсан зөвлөмжийг талуудад хүргэсэн.</p> <p>– “Жендэр ба хөгжил” хандлагын хүрээнд ололт амжилт, туршлагаа солилцох, “Эх дэлхийгээ шинэчилье: 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр”-т туссан жендэрийн тэгш байдлыг хангах зорилтыг хэрэгжүүлэхэд олон улсын хамтын ажиллагааны платформ үүсгэх, жендэрийн тэгш байдлын талаарх олон нийтийн ойлголт, мэдээллийг нэмэгдүүлэх, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, үндэсний хөтөлбөрийг сурталчлах зорилго бүхий “Тогтвортой хөгжлийн зорилт: Жендэр ба хөгжил” сэдэвт олон улсын бага хурлыг Монгол Улсын Ерөнхий сайд, Жендэрийн үндэсний хорооны даргын ивээл дор, гадаадын дипломат төлөөлөгчийн газрууд, Нэгдсэн үндэсний байгууллага болон түүний төрөлжсөн байгууллагууд, олон улсын банк, санхүүгийн байгууллагууд,</p>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
		<p>олон улсын байгууллагын Монгол Улс дахь төлөөлөгчийн газрууд, төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл нийт 350 гаруй зочид төлөөлөгчтэйгөөр 2018 оны 06 дугаар сарын 27–28–ны өдрүүдэд зохион байгууллаа. Бага хурлын үеэр, Зохистой хөдөлмөр эрхлэлт, хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг дэмжих жендэрийн түншлэл, хамтын ажиллагаа; Амьдралын чанарыг дээшлүүлэхэд жендэрийн шалгуур үзүүлэлтүүдийг үндэсний болон олон улсын түвшинд ашиглах боломж, арга зам; Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдлийг бууруулах, хөдөөгийн охид эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах олон улсын түншлэл хамтын ажиллагаа зэрэг сэдэвчилсэн хуралдаанууд зохион байгуулагдлаа. Хуралдаанд, Канад улсын Засгийн газрын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын жендэрийн ахлах зөвлөх Шон Хайс, Япон улсын “Эмэгтэйчүүдийн хяналт” ТББ–ын дэд дарга Юкико Ода, БНСУ–ын Эмэгтэйчүүдийн хөгжлийн хүрээлэнгийн захирал Юн Ха Чанг, Австрали улсын Флиндерсийн Их сургуулийн доктор Ивонн Коркоран–Нантес нарын жендэр судлалаар олон улсад танигдсан судлаач, шинжээч нар уригдан оролцсон. Бага хурлаас, жендэрийн тэгш байдлыг хангах зорилтыг хэрэгжүүлэхэд олон улсын хамтын ажиллагааны платформ үүсгэхэд чиглэсэн Улаанбаатар тунхагийг дэвшүүллээ.</p> <p>– Жендэрийн талаарх олон нийтийн хэвшмэл ойлголтыг халж, жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг, хандлагыг дээшлүүлэх, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, үндэсний хөтөлбөрийг сурталчлахад чиглэсэн сэтгүүл зүйн болон гэрэл зургийн шилдэг бүтээлийн уралдааныг 2018 оны 02 дугаар сарын 20–ны өдрөөс 05 дугаар сарын 18–ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгууллаа. Уралдаанд эрэгтэй, эмэгтэй хүйсийн аль алины асуудлыг хөндсөн</p>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
		<p>төдийгүй боловсрол, эрүүл мэнд, гэр бүл, хүчирхийлэл, эдийн засаг, уул уурхай, улс төр, хууль эрх зүйн салбар дахь жендэрийн олон талт байдлыг хөндсөн 50 гаруй оролцогчийн 100 орчим сурвалжлага, мэдээллийн хөтөлбөр, нэвтрүүлэг, асуудал хөндсөн цуврал нийтлэл, гэрэл зургийн бүтээл өрсөлдөж шилдгүүдээ тодрууллаа.</p> <p>– Жендэрийн үндэсний хорооны <a href="http://www.gender.gov.mn">www.gender.gov.mn</a> цахим хуудсыг сүлжээнд байршуулж, ажиллуулж эхлээд байна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, үндэсний хөтөлбөрийг сурталчлах, жендэрийн тэгш байдлын талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээний талаарх мэдээ мэдээллийг тухай бүр цахим хуудаст байршуулан ажиллаж байна.</p> <p>– Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, үндэсний хөтөлбөрийг сурталчлах зорилгоор видео танилцуулгыг монгол болон англи хэлээр, “Эмэгтэйчүүдийн алагчилах бүх хэлбэрийг устгах тухай” НҮБ-ын конвенцийн зөвлөмжийн танилцуулгыг монгол хэлээр бэлтгэсэн. Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хүргэх ажлыг хуваарийн дагуу хийж гүйцэтгэнэ.</p> <p>– Салбар, орон нутгийн алсын хараа, бодлого, үйл ажиллагааг дэмжсэн жендэрийн бодлогыг боловсруулан батлах ажлын хүрээнд, “Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт жендэрийн талаар баримтлах бодлого”-ыг БСШУС-ын Сайдын 2017 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн А/130 тоот тушаалаар, “Барилга хот байгуулалтын салбарт жендэрийн талаар баримтлах бодлого”-ыг Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 208 дугаар тушаалаар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт жендэрийн талаар баримтлах бодлогыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлого”-ыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн А-94 дүгээр тушаалаар, “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын</p>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
		<p>хүрээний хууль сахиулах байгууллагуудын жендэрийн нэгдсэн бодлого”-ыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/117 дугаар тушаалаар, “Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт жендэрийн талаар баримтлах бодлого”-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/177 дугаар тушаалаар тус тус баталлаа. Эдгээр салбарын жендэрийн нэгдсэн бодлогыг танилцуулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд дээрх салбаруудын 290 орчим ажилтан, албан хаагчдыг хамруулан 6 удаагийн сургалт, семинарыг зохион байгуулснаас гадна дэд хөтөлбөрийг англи, монгол хэлээр хэвлэн хүргүүлсэн. Мөн аймгуудын 43 хувь нь орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцсэн жендэрийн дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна. 2018 онд 7 аймаг жендэрийн дэд хөтөлбөрөө боловсруулан батлахаар төлөвлөөд байна.</p>
	<p>108.45. Эмэгтэйчүүдэд тэгш байдал, хамгаалалтыг олгож буй хууль тогтоомж, үр нөлөөтэй хэрэгжилтийг баталгаажуулах арга хэмжээгээ гүнзгийрүүлэх /Аргентин/</p>	<p>108.44-ийг үзнэ үү.</p>
	<p>108.46. Эмэгтэйчүүдийн эрхийн хамгаалалтыг сайжруулах чиглэлээрх хүчин чармайлтаа үргэлжлүүлэх /БНАСУ/</p>	<p>108.43-ыг үзнэ үү.</p>
	<p>108.47. Төрийн албан дахь эмэгтэйчүүдийн оролцоо, жендэрийн тэгш байдлыг хангах ажлаа үргэлжлүүлэх /Лаос/</p>	<p>Төрийн албан хаагчдын жендэрийн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэхээр жендэрийн цахим сургалтын модулийг нэвтрүүлээд байна. Үндсэн 3 модультай, суралцагч өөрийн тохиромжтой цаг хугацаа, орон зайд суралцах боломжийг бүрдүүлсэн энэ модулийг цаашид улам хөгжүүлэх бөгөөд төрийн удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтын журамд энэ сургалтын сертификатыг авсан байх шаардлагыг тусгахаар төлөвлөж байна. Цахим сургалтыг Сангийн яам болон түүний харьяа байгууллага, агентлагийн удирдах ажилтнуудад зохион байгуулан туршиж, санал авч, сайжруулсан.</p>



<b>№</b>	<b>Зөвлөмж</b>	<b>Хэрэгжилтийн явц</b>
	<p>108.48. Нийгэм, эдийн засгийн амьдрал дахь эмэгтэйчүүдийн идэвхитэй, бүрэн оролцоог цаашид дэмжих бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх /Сингапур/</p>	<p>Аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллагад ажиллагчдын мэдээллийг хүйсийн ялгаатайгаар өргөжүүлэн баяжуулах, жендэрийн статистикийг бодлого, үйл ажиллагаандаа уялдуулан хэрэглэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор жендэрийн тоо бүртгэлийн тусгай цахим мэдээллийн санг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэхээр ажиллаж байна.</p> <p>Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрт Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимтай хамтран шилдэг аж ахуйн нэгж шалгаруулах шалгуурт жендэрийн эрх тэгш байдлын үзүүлэлтийг тусгах; ажил олгогч, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих хөшүүргийг тодорхойлж сурталчлах; жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр үр дүнтэй ажилласан аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдийн үйл ажиллагааг сурталчлах, туршлагыг түгээн дэлгэрүүлэн урамшуулах зэргээр аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах талаар тусгасан. Энэ хүрээнд уул уурхай, хөдөө аж ахуйн 2 аж ахуйн нэгжийг сонгон авч, компанийн жендэрийн бодлого боловсруулах, түүн дээр үндэслэн удирдамж боловсруулах ажлыг эхлүүлсэн ба энэхүү ажлыг Азийн хөгжлийн банкны техник туслалцааны төслөөс санхүүжүүлж байна.</p> <p>Аж ахуйн нэгж, байгууллагаар хүйсийн тэнцвэрт байдлын талаарх тайлан гаргуулах, жендэрийн тэгш байдлын хороо байгуулах талаар зарим санаачилгыг гаргаж эхэлж байна. Тухайлбал, 2017 онд Эрдэнэс таван толгой ХК дэргэдээ Жендэрийн хороо байгуулж, улмаар Жендэрийн үндэсний хороо, түүний ажлын албанд хандаж сургалт зөвлөгөө авч, байгууллагын стратеги төлөвлөлтөд жендэрийн асуудлыг тусгах талаар хамтран ажилласан нь үр дүнтэй ажил боллоо.</p> <p>Энэ ажлын туршлагад үндэслэн цаашдаа аж ахуйн нэгж, байгууллагаас, ялангуяа, томоохон аж ахуйн нэгжид хүйсийн тэнцвэрт байдлын талаарх тайланг боловсруулах туршилтыг хийхээр төлөвлөж байна.</p>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.49. Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдлын асуудлаарх Аюулгүйн зөвлөлийн 1325 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх үндэсний төлөвлөгөө батлах асуудлыг судлан үзэх /Португал/</p>	<p>НҮБ–ын Аюулгүйн зөвлөлийн 1325 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх үндэсний төлөвлөгөө батлах асуудлыг судалж үзэх хүрээнд ГХЯ тогтоолыг монгол хэлээр орчуулж, тогтоолын хэрэгжилт, холбогдох асуудлаар мэдээлэл авах, үндэсний чадавхийг бэхжүүлэхэд анхаарч ажиллав. Энэ хүрээнд “НҮБ–ын АЗ–ийн Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдлын асуудлаарх 1325 дугаар тогтоол: Хэрэгжилт, үндэсний түвшинд Үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж буй туршлага, сургамж” сэдвээр судалгаа хийснээс гадна, 2017.IX сард ХБНГУ–ын Фридрих Эбертийн сан, Солонгосын эмэгтэйчүүдийн хөгжлийн хүрээлэнгээс хамтран Сөүл хотноо зохион байгуулсан “Эмэгтэйчүүд, энх тайван аюулгүй байдал” сэдэвт олон улсын хурал, 2018.IV.19–20–нд Вена хотод ЕАБХАБ–ын Жендэрийн хэлтсээс зохион байгуулсан “Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдал” сэдэвт сургалт, мөн 2018.V.24–25–нд Бээжин хотноо НҮБ–ын Улс төрийн газраас зохион байгуулсан “Зүүн Хойд Ази дахь эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдлын асуудал” сэдэвт бүс нутгийн семинарт ГХЯ, БХЯ мөн ХЗДХЯ–ны экспертүүд оролцов. Түүнчлэн 2018.V сараас Уганда Улсын Энтеббе хотод болж буй “НҮБ–ын цэргийн эмэгтэй алба хаагчдын дамжаа”–нд анх удаа Монгол Улсын Зэвсэгт хүчний офицер эмэгтэй суралцаж эхэллээ. Энэ мэдлэг, экспертиз дээр тулгуурлан зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр судалгааны ажлыг үргэлжлүүлж байна.</p>
	<p>108.50. Арьс үндэс, яс үндсээр ялгаварлан гадуурхахыг өдөөн хатгасан үзэн ядах үг хэлэх үйлдэлтэй болон үүнээс улбаатай хүчирхийлэлтэй тэмцэх /Хятад/</p>	<p>Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.51. Гэр хороололд амьдарч буй хүмүүсийн эсрэг шууд болон шууд бусаар ялгаварлан гадуурхах явдалтай тэмцэх үр нөлөөтэй арга хэмжээг авах /Швед/</p>	<p>Улсын Их Хурал 2015 оны 6 дугаар сарын 26–ны өдөр “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай” хуулийг баталж, гэр хорооллыг хөгжүүлэх үйл ажиллагаа болон гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлсэн.</p> <p><b>“Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх талбайг сонгох үлгэрчилсэн журам”</b>–ыг боловсруулж, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 84 дүгээр тушаалаар батлан захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг Улсын нэгдсэн бүртгэлийн 3644 тоотод, “Гурван талт гэрээний үлгэрчилсэн загвар”–ыг боловсруулж, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 125 дугаар тушаалаар батлан захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг Улсын нэгдсэн бүртгэлийн 3658 тоотод, <b>“Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам”</b>–ыг боловсруулж, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 126 дугаар тушаалаар батлан захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг Улсын нэгдсэн бүртгэлийн 3656 тоотод тус тус бүртгүүлсэн.</p> <p><b>“Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журам”</b>–ын төслийг боловсруулж, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 06 дугаар сарын 30–ны өдрийн 122 дугаар тушаалаар батлан захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр ажиллаж байгаа.</p> <p><b>“Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах үйл ажиллагааны журам”</b>–ын төслийг боловсруулж, аймгуудыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, мэргэжлийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн төлөөллийн байгууллагаас санал авах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.51. Гэр хороололд амьдарч буй хүмүүсийн эсрэг шууд болон шууд бусаар ялгаварлан гадуурхах явдалтай тэмцэх үр нөлөөтэй арга хэмжээг авах /Швед/</p>	<p>– Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд нийт 1510 нэгж талбарын газрыг чөлөөлөн 10158 айлын орон сууцны барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. Төслийн хүрээнд нийт 5197 айлын орон сууцыг тус тус ашиглалтад оруулж гэр хорооллын 1024 өрхийг шинэ орон сууцаар хангаад байна.</p> <p>Төслийн хүрээнд газар чөлөөлсөн боловч тохилог орон сууцаар хангагдаж чадаагүй иргэдийг түр оршин суух байраар хангах зорилт тавин ажиллаж байна. Тус зорилтын үр дүнд Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороонд 132 айлын орон сууц, 14 дүгээр хороонд 50 айлын орон сууцыг түр оршин суух байрны зориулалтаар ашиглахаар нийслэлийн өмчид шилжүүлэн иргэдийг амьдрах нөхцөлийг хангаж байна. Өнөөгийн байдлаар 76 нэгж талбарын иргэд түр оршин суух байранд амьдарч байгаа бол 376 нэгж талбарын иргэд түрээсийн байранд амьдарч байна. Цаашид түр оршин суух байрыг 500 болгон нэмэгдүүлэх зорилт тавиад байгаа бөгөөд 2018 онд дахин 132 айлын орон сууцыг ашиглалтад оруулан газар чөлөөлсөн иргэдийг түр оршин суух байраар хангахаар төлөвлөөд байна.</p>
	<p>108.52. Гадаадын иргэдийг аливаа хэлбэрийн халдлагаас хамгаалах, гэмт этгээдэд хариуцлага хүлээлгэх хүчин чармайлтаа ахиулах /БНСУ/</p>	<p>ГХЯ–ны Консулын газар, Хууль зүйн туслалцаа үзүүлэх төв хамтран 2018 оны 3 дугаар сарын 1–ний өдөр “Гадаадын иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн орчин” сэдвээр хурал зохион байгуулж, англи, герман, хятад, солонгос, орос хэлээр гадаад иргэдэд үнэгүй зөвлөгөө өгөх төвийн үйл ажиллагааг танилцуулсан. Уг арга хэмжээнд Улаанбаатар дахь гадаадын 18 дипломат төлөөлөгчийн газрын консулууд болон ХЗДХЯ, ЦЕГ, ГИХГ–ын албаны хүмүүс оролцсон болно.</p> <p>Хууль зүйн туслалцааны төв нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжоор баталгаажсан иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах зорилгоор “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай” хуулийн хүрээнд төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтанд үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх, хууль</p>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
		<p>зүйн зөвлөгөө өгөх чиг үүргийг хэрэгжүүлэгч төрийн байгууллага бөгөөд энэхүү чиг үүргийн хүрээнд гадаадын иргэдэд мөн адил хууль зүйн туслалцаа үзүүлэн ажилладаг ба гадаадын иргэдэд үзүүлж буй хууль зүйн туслалцааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2018 оноос эхлэн гадаад хэлээр хууль зүйн зөвлөгөө өгөх ажлыг Монголын Хуульчдын холбоотой хамтран зохион байгуулж байна. Нийслэлийн Засаг даргын “Аз жаргалтай хот” мөрийн хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн Аялал Жуулчлалын газар, Монголын Оюутны холбоотой хамтран оюутан залуучуудыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах, аялал жуулчлалаар яваа гадаадын иргэдийн аюулгүй байдлыг хангах, жуулчдад аялал жуулчлал, соёлын үйлчилгээний мэдээлэл түгээх “Оюутан цагдаа” арга хэмжээг жил бүрийн 06 дугаар сарын 08–ны өдрөөс 08 дугаар сарын 15 хооронд 4 дэх жилдээ зохион байгуулж байна. Арга хэмжээг сурталчлах чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн төвтэй хамтран сурвалжлага, нэвтрүүлэг хийлгэж, үйл ажиллагааг “TV-5”, “TV-9”, “ETV”, “UBS”, “Star” зэрэг 8 телевиз, Цагдаагийн ерөнхий газар, тус газрын цахим хаяг болон facebook хаяг, “Zaluu.mn”, “Medee.mn” зэрэг 9 сайтуудыг ашиглаж байна.</p> <p>Орон нутагт Баян-Өлгий аймагт 1, Дархан-Уул аймагт 2, Дорнод аймагт 2, Завхан аймагт 2, Архангай аймагт 5, Хэнтий аймагт 1, нийт 5 их, дээд сургууль, 2 мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд оюутан залуучуудыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах зорилгоор 145 гишүүнтэй “Оюутан цагдаа бүлгэм” ажиллаж байна. “Оюутан цагдаа” бүлгэм, “Оюутан цагдаа”-ийн үйл ажиллагаанд нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагаас зааварчлага, зөвлөмж өгч, хамтран ажиллаж байна. –Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох эрх зүйн актын хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөгч, тус улсад түр ирэгч, албан болон хувийн хэргээс оршин суугч гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын</p>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
		<p>нутаг дэвсгэрт хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх, аливаа хэлбэрийн халдлагаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль хяналтын байгууллагад хандах талаар үйлчилгээний зааланд үйлчлүүлсэн иргэд болон хяналт шалгалтад хамрагдсан гадаадын иргэдэд тухай бүр сурталчилж, сурталчилгааны материал, санамж бэлтгэн үйлчилж байна.</p>
108.53.	<p>Бэлгийн чиг баримжаа, эсхүл хүйсийн баримжаа, илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтыг оролцуулан ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэртэй тэмцэх /Франц/</p>	<p>108.55–ыг үзнэ үү. Мөн UPR Trust Fund–ын төслийн хүрээнд ЛГБТ хүмүүсийн эрхийг хамгаалах НҮБ–ын “Free and equal campaign”–ыг Монгол Улсад албан ёсоор эхлүүлэх, ЛГБТ хүмүүсийн эрхийг хүндэтгэх, хамгаалах асуудлаар олон нийтийн дунд мэдээлэл, ухуулга сурталчилгаа хийж, шүүх, прокурорын байгууллагын ажилтнуудад сургалт зохион байгуулах” –аар төлөвлөөд байна.</p>
108.54.	<p>ЛГБТИ хүмүүсийн хүний эрхийн үр нөлөө бүхий хамгаалалт тогтоосон хууль тогтоомжийг боловсруулж батлахаас гадна Нэн ядуурал ба хүний эрхийн асуудлаарх Тусгай илтгэгчийн илтгэлд дурдсан ЛГБТ хүмүүсийн эсрэг үйлдсэн гэх халдлагуудыг хараат бус байдлаар мөрдөн шалгах арга хэмжээ авах /Гондурас/</p>	<p>“Бэлгийн болон хүйсийн чиг баримжаагаар ялгаварлан гадуурхах” үйлдлийг гэмт хэрэгт тооцсон ба Эрүүгийн хуулийн 14.1 дүгээр зүйлээр зохицуулсан. Цагдаагийн байгууллагад алба хаагчдын харилцааны соёл, ёс зүй, хүнд суртлын талаарх гомдол, мэдээллийг иргэдээс 24 цагийн турш авахаар 126 тусгай дугаарын утсыг ажиллуулж байна. Цагдаагийн байгууллагад хандсан 6 тохиолдлоос эрүүгийн хэрэг үүсгэсэн 3, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан 3 байна. ЛГБТ иргэд ямар ч тохиолдолд өөрийгөө аль болохоор нууцалдаг учир гомдол мэдээлэл нь цагдаагийн байгууллагад анх бүртгэгдэхдээ ЛГБТ хүмүүсийн бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаанаас шалтгаалсан гэж бүртгэгдээгүй агсам тавьсан зодолдсон гэх дуудлага мэдээллээр бүртгэгдэн шалгагдсан байна.</p>
108.55.	<p>Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтыг оролцуулан ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэрийг хориглох /Словени/</p>	<p>Эрүүгийн хуулиар “ялгаварлан гадуурхах” үйлдлийг гэмт хэрэгт тооцсон.</p>

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	108.56. Бэлгийн чиг баримжаа, хүйсийн байдал болон эрүүл мэндийн байдалд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтыг оролцуулан ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэрийг хориглох /Зүүн Тимор/	108.55–ыг үзнэ үү.
	108.57. Өөрийн үндэсний хууль тогтоомждоо тусган оруулах замаар ЛГБТИ хүмүүс эрхээ эдлэх тэгш байдлыг хөхиүлэн дэмжих /Уругвай/	108.55–ыг үзнэ үү. Эрүүгийн хуульд ялгаварлан гадуурхах гэмт хэргийг тусгахдаа “бэлгийн болон хүйсийн чиг баримжаагаар” ялгаварлан гадуурхах үйлдлийг хамруулахаар заасан нь ЛГБТИ хүний эрхийг хамгаалах маш том хууль зүйн хөшүүрэг юм.
	108.58. Үзэн ядах, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхах гэмт хэргүүдийг эрүүгийн хууль тогтоомждоо оруулах зорилгоор тухайн хууль тогтоомжийг өөрчлөх /Испани/	108.55, 108.57–г үзнэ үү.
	108.59. ЛГБТ хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхалт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, ийм явдлыг үл тэвчих хандлагыг дэмжих зорилгоор олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх сурталчилгааны ажлыг зохион байгуулах /Бразил/	<p>“Жендерийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого үйл ажиллагаандаа тусгах нь” сэдвийн хүрээнд ЛГБТ хүмүүсийн эрхийг хамгаалах сургалтыг Хууль сахиулах байгууллагын 30 удирдах албан тушаалтанд зориулан зохион байгуулав. Одоогоор ЛГБТ иргэдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг бүртгэгдээгүй бөгөөд цагдаагийн байгууллагаас ЛГБТ төвтэй мэдээ, мэдээлэл солилцож, хамтран ажиллаж байна. ЛГБТ иргэдтэй холбоотой, биеэ үнэлсэн, гудамж талбай, олон нийтийн газар танхайрсан зөрчлүүд цагдаагийн байгууллагад бүртгэгдэж хуулийн дагуу шалгаж шийдвэрлэсэн.</p> <p>Боловсролд бүх төрлийн ялгаварлан гадуурхалаас урьдчилан сэргийлэх, ялангуяа цахим орчинд аливаа төрлийн ялгаваралд суралцагчдыг өртүүлэхгүй байх, сурагчдын бусдыг ойлгох чадварыг хөгжүүлэх, дэмжих зорилгоор хүүхдийн оролцоонд тулгуурлан цахим орчин дахь хүүхэд хамгааллын үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулж байна.</p>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.60. Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлтэй тэмцэх хүчин чармайлтаа сайжруулж, энэ чиглэлээрх датаг цуглуулах, мэдээлэл, статистикийг гаргах ажлыг зохион байгуулалттайгаар хийж гүйцэтгэх /Нидерланд/</p>	<p>Цагдаагийн ерөнхий газар гэмт хэрэг, зөрчлийн шалгах процессын мэдээллийн нэгдсэн сан, тайлан мэдээний програм хангамжид шинэчлэл хийх ажлыг эхлүүлсэн. Шинээр бүрдүүлэх мэдээллийн сангийн жагсаалтад ЛГБТ хүмүүсийг бүртгэл, ялгаварлан гадуурхалтын хэлбэр багтсан бөгөөд уг мэдээллийн санг ашиглан ялгаварлан гадуурхахтай тэмцэх ажилд ашиглахаар төлөвлөн ажиллаж байна.</p>
	<p>108.61. Өмнөх удаа зөвлөмж болгож байсанчлан ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэрийг, тэр дундаа ХДХВ/ДОХ-той гэсэн үндэслэлээр ялгаварлан гадуурхахыг эрс хориглох, урьдчилан сэргийлэх, шийтгэх, болон устгах зорилготой хууль тогтоомжийг батлах зэргээр үр нөлөөтэй, шуурхай арга хэмжээ авах /Мексик/</p>	<p>Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуульд зааснаар “ХДХВ, ДОХ-той хүнд болон түүний эхнэр, нөхөр, гэрлэлтээ бүртгүүлээгүй боловч хамтын амьдралтай байгаа хүн, эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчид зөвлөгөө өгөх, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам”-ыг Эрүүл мэндийн сайдын 2017 оны 305 дугаар тушаалын “БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тусламж үйлчилгээ үзүүлэх журам”-ын 4 дүгээр хавсралтаар батлуулан мөрдөн ажиллаж байна.</p> <p>Эрүүл мэндийн сайдын 2009 оны 241 дүгээр тушаалын хавсралтын “Халдварт өвчинтэй жирэмсэн эмэгтэй амаржих тасаг”-т үйлчлүүлэх өвчний заалтын 6 дахь заалтад ХДХВ/ДОХ-той жирэмсэн эхийг харьяалал харгалзахгүй ХӨСҮТ-д төрүүлнэ гэж заасан нь хүний эрхийг зөрчсөн ялгаварлан гадуурхсан эх нярайн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг чанартай авах боломжгүй, эх болон түүний ар гэрийн сэтгэлзүй, нууцлалын байдалд сөргөөр нөлөөлж байсан. Үүнийг Эрүүл мэндийн сайдын 2017 оны 305 дугаар тушаалаар “БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тусламж үйлчилгээ үзүүлэх журам”-д мэргэжлийн тусламж үйлчилгээг харьяаллын дагуу үзүүлэхээр болсон. ХДХВ/ДОХ-той өвчтөнд хөнгөвчлөхийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг ээлтэй чанартай үзүүлэх зорилгоор Глобал сангийн санхүүжилтээр ХӨСҮТ-д 4 ортой сүүлийн үеийн тоноглол бүхий тасаг байгуулж эмч эмнэлгийн мэргэжилтнийг сургасан.</p>



**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

<b>№</b>	<b>Зөвлөмж</b>	<b>Хэрэгжилтийн явц</b>
	<p>108.61. Өмнөх удаа зөвлөмж болгож байсанчлан ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэрийг, тэр дундаа ХДХВ/ДОХ–той гэсэн үндэслэлээр ялгаварлан гадуурхахыг эрс хориглох, урьдчилан сэргийлэх, шийтгэх, болон устгах зорилготой хууль тогтоомжийг батлах зэргээр үр нөлөөтэй, шуурхай арга хэмжээ авах /Мексик/</p>	<p>Канадын ЭСЯ–ны санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Улаанбаатар хот дахь эрсдэлт бүлгийн хүн ам болох эмэгтэй биеэ үнэлэгчид, эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд болон ХДХВ, ДОХ–той амьдарч буй хүмүүст үзүүлэх бэлгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах нь” сэдэвт төслийн хүрээнд:</p> <p>ХДХВ, ДОХ–той хүмүүс болон түүний ар гэр, хамтран амьдрагчид ганцаарчилсан болон хосын зөвлөгөө өгөх үйлчлүүлэгчийн нууцыг хадгалсан бүлгийн ярилцлагын өрөө байгуулан тохижуулсан, ХДХВ, ДОХ–той хүмүүс нь хоорондоо уулзалж тулгарч буй бэрхшээл болон асуудлаа ярилцаж, дэмжих бүлгийн уулзалт хийх, жижиг хэмжээний сургалт зохион байгуулах боломжтой болсон, “Солонго” кабинетаар үйлчлүүлж буй бэлгийн цөөнх эрэгтэйчүүдэд үзүүлэх бэлгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарт эерэгээр нөлөөлөх, үйлчлүүлэгчид ээлтэй орчинг бүрдүүлсэн, Уртасгасан цагаар эмэгтэй биеэ үнэлэгчдэд бэлгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөх орчин болон тус кабинетаар үйлчлүүлж буй эмэгтэйчүүдийн хувьд хувцас солих мөн хүлээлгийн өрөөтэй болсноор үйлчилгээ авах таатай орчин бүрдсэн.</p> <p>2016 оны Эрүүл мэнд, спортын сайд болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар хүнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шинэчлэн тогтоож одоогоор 78 хүнд хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоогоод байна. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн богино хугацааны сургалтуудад Бэлгийн чиг баримжаа хүйсийн баримжааны илэрхийлэл, ялгаварлан гадуурхалт гутаан доромжлолын талаар тасралтгүй зааж байна.</p>

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	108.62. Монгол Улс соёрхон баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын Цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт II протоколд нийцүүлэн цаазаар авах ялыг халж хуульчлан баталгаажуулах /Франц/	108.2–ыг үзнэ үү.
	108.63. Цаазаар авах ялыг бүрэн халсан хууль тогтоомж батлах /Австрали/	108.2–ыг үзнэ үү.
	108.64. Цаазаар авах ялыг бүрэн халах зорилгоор Эрүүгийн хуулиа өөрчлөх /Итали/	108.2–ыг үзнэ үү.
	108.65. Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд цаазаар авах ялыг эцэслэн халах /Англи/	108.2–ыг үзнэ үү.
	108.66. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколыг соёрхон баталснаар хүлээсэн олон улсын үүргээ биелүүлэх үүднээс цаазаар авах ялыг халах хүрээнд эрүүгийн хууль тогтоомжоо шинэчлэх /Швед/	108.2–ыг үзнэ үү.
	108.67. Цаазаар авах ялыг хуулиар халах зорилгоор шинэ Эрүүгийн хуулийг оролцуулан шаардлагатай хууль тогтоомжийг батлах /Словак/	108.2–ыг үзнэ үү.
	108.68. Бүх төрлийн гэмт хэрэгт цаазаар авах ялыг de jure байдлаар оногдуулахгүй болгож халах /Монтенегро/	108.2–ыг үзнэ үү.
	108.69. Цаазаар авах ялыг халж, цаазаар авахуулсан хүмүүсийн гэр бүлийг нууцаас хассан холбогдох мэдээллээр хангах /Литва/	Судалж байна.

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	108.70. Цаазаар авах ялын гүйцэтгэлийг улсын нууц мэдээллээс хасах /Португал/	Судалж байна.
	108.71. Хууль сахиулах албан хаагчид болон бусад төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр, мөн шүүгч, хуульч нарын байнгын сургалтын хөтөлбөрт эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх олон улсын зохицуулалтыг тусгах /Мексик/	<p>“Цагдаагийн ажил – Хүний эрх” сэдэвт хичээлийг Хууль сахиулахын их сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгуулан, 2 дугаар дамжааны сонсогчдод 2 кредит буюу 56 цагийн хичээл заадаг болсон. Энэ хичээлээр Эрүү шүүлт тулгах гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн талаар тусгайлсан хөтөлбөрөөр хичээл заагдаж байна.</p>
		<p>2018 оны Хууль сахиулахын Их сургуулийн захирлын тушаалаар “Хорих байгууллагын аюулгүй байдал–Хууль сахиулах ажил” бакалаврын зэрэг олгох сургалтын хөтөлбөрийг шинэчлэн баталсан бөгөөд заавал судлах сургалтын хөтөлбөрт “Хүний эрх” хичээлийг 96 цаг буюу 2 кредит/цаг байхаар тусган хэрэгжүүлж байна.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 05–ны өдрийн А/249 дүгээр тушаалаар баталсан “2018 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд зохион байгуулах мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө”–ний хүрээнд сургалтад хамрагдаж буй нийт алба хаагчдад хүний эрхийн хичээл сургалтуудыг зохион байгуулж байна.</p>
		<p>2017 оны 11 дүгээр сарын 29–нөөс 12 дугаар сарын 01–ний өдрүүдэд Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, Монголын хуульчдын холбоотой хамтран “Хорих байгууллага ба хүний эрх” сэдэвт сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгууллаа. Алба хаагчдын хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлага, төлөвшлийг бий болгоход чиглэсэн тус сургалтад хорих анги, байгууллагуудаас нийт 34 алба хаагч хамрагдсан.</p>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.71. Хууль сахиулах албан хаагчид болон бусад төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр, мөн шүүгч, хуульч нарын байнгын сургалтын хөтөлбөрт эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх олон улсын зохицуулалтыг тусгах /Мексик/</p>	<p>НҮБ-ын Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх дэд хорооноос өгсөн зөвлөмжийн хүрээнд 2017 оны 10 дугаар сарын 20-ны өдөр нийт хорих анги, байгууллагад ажиллаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулж НҮБ-аас баталсан <b>“Стамбулын протокол”</b>-ыг танилцуулан, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар харьцсан тохиолдолд эмч, эмнэлгийн мэргэжилтний хүлээх үүрэг, хариуцлагын талаар тодорхой ойлголт, мэдлэгийг өгсөн болно.</p> <p>Мөн Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг дахин гаргуулахгүй байх чиглэлээр Мөрдөн байцаах албаны сургалтын төлөвлөгөөнд тусгаж, төлөвлөгөөний дагуу Тусгай субъектын үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтсийн алба хаагч нар эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, “Эрүү шүүлт тулгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Нотлох баримтыг хуурамчаар үйлдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сэдвээр мөрдөгч нарт сургалт зохион байгуулж байна. Сургалтад давхардсан тоогоор 168 мөрдөгч хамрагдаад байна. <b>Хууль сахиулах их сургуулийн <a href="http://www.leu.gov.mn">www.leu.gov.mn</a> цахим хуудасны “Зайн сургалт, файлын сан” хэсэгт Хууль сахиулахын их сургуулийн зайн сургалтын систем /MOO-DLE/”</b> холбоосыг шинээр нээж, <a href="http://elearning.leu.edu.mn/">elearning.leu.edu.mn/</a> <b>цахим хуудастай холбон</b> эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний нэмэлт протоколын талаарх <b>сургалт, сурталчилгааны материалыг тогтмол байршуулж байна.</b></p>

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.72. Эрүүдэн шүүсэн байж болзошгүй бүх хэргийг мөрдөн шалгах, хорих байрны болон шоронгийн барилга байгууламжийн нөхцлийг сайжруулах, эрүүдэн шүүгдсэний улмаас хохирсон хохирогчдод эдлэх эрх зүйн хамгаалалтыг бэхжүүлэх /Чех/</p>	<p>108.82–ыг үзнэ үү. Шинэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1 дүгээр зүйл <b>/Хохирол арилгуулах эрх/</b>– д “Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд нь мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эрүүл мэнд, сэтгэл санааны үр дагаврыг арилгуулах болон тэтгэвэр, тэтгэмж авах, орон сууц эзэмших болон бусад эрхээ нөхөн сэргээлгэх эрхтэй” гэж хуульчилсан.</p>
	<p>108.73. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх цагдаагийн албан хаагчдын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлэх, мөн энэ хэрэгт ял шийтгэлгүй үлдэх явдалтай тэмцэх үүднээс мөрдөн шалгах үр нөлөө бүхий тогтолцоог бий болгох /Франц/</p>	<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагын талаар заасан ба мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Тагнуул, цагдаа, авлигатай тэмцэх байгууллагын албан хаагчийн үйлдсэн гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах харьяаллыг прокурор тогтооно” гэж заасан. Дээр дурдсан байгууллагууд өөрийн албан хаагчийн үйлдсэн гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулахгүй байх зорилгоор харьяаллыг прокурор өөрчлөн тогтоох юм. Үүний дагуу Улсын Ерөнхий Прокурорын 2017 оны а/67 тоот тушаалаар баталсан аргачилсан зааварт цагдаагийн байгууллагын алба хаагч нарын үйлдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэгт Авлигатай тэмцэх газар, шүүгч прокурор, авлигатай тэмцэх газрын алба хаагч нарын үйлдсэн албан тушаалын эсрэг гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл, эрүүгийн хэргээс бусад төрлийн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэгт Мөрдөн байцаах алба мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар зохицуулсан. 2018 оны 3 дугаар сард Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийг өөрчлөн байгуулсан бөгөөд төвийн 2018 оны сургалтын төлөвлөгөөнд 119 удаагийн 5236 цагийн багтаамжтай сургалтад 7648 алба хаагчийг хамруулахаар төлөвлөснөөс 2018 оны эхний 5 сарын байдлаар 42 удаагийн сургалтад 1203 алба хаагчид хамруулсан ба Хүний эрхийн чиглэлээр 36 удаагийн сургалтад 114 цагийн сургалтыг төлөвлөөд байна.</p>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
		<p>Хүний эрхийн Үндэсний Комисс, Цагдаагийн ерөнхий газартай хамтран байгуулсан “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны Б/58, 2018 оны А/46 дугаар тушаалуудаар баталсан “Цагдаагийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2017, 2018 оны сургалтын төлөвлөгөө”-ний дагуу “Хүний эрхийн сургагч багш бэлтгэх” 1, 2 дугаар ээлжийн сургалтыг зохион байгуулж, нийт 51 алба хаагч хамрагдан, “Сургагч багш”-ийн гэрчилгээг гардуулж, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны “Сургагч багшаар ажиллуулах тухай” Б/354 дүгээр тушаалаар төв, орон нутгийн цагдаагийн 41 байгууллагын 49 сургагч багшийг томилон ажиллуулж байна.</p> <p>Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн 2018 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулж давтан болон мэргэшүүлэх нийт 15 удаагийн 30 цагийн сургалтад 152 алба хаагч хамрагдсан байна.</p>
108.74.	<p>Эрүүдэн шүүх үйлдлийг гэмт хэрэг хэмээн тодорхойлсон өөрчлөлтийг Эрүүгийн хуульд оруулах асуудлыг судлан үзэх /Унгар/</p>	<p>Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд “эрүү шүүлт тулгах” үйлдлийг гэмт хэрэгт тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр, мөн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “эрүүдэн шүүсний улмаас хүний амь нас хохирсон бол 12–20 жил, эсхүл бүх насаар хорих ял” оногдуулахаар, мөн хуулийн 11.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “эрүүдэн шүүж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан бол 5–12 жил хорих ял” оногдуулахаар тус тус хэргийн нөхцөл байдлын харгалзан хүндрүүлэхээр заасан.</p>
108.75.	<p>Соёрхон батлаад удаагүй байгаа Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколд заасан шаардлагын дагуу эрүүдэн шүүсэн болон зүй бусаар харьцсан байж болзошгүй хэргийг мөрдөн шалгах бие даасан тогтолцоог байгуулах /Австри/</p>	108.73–ыг үзнэ үү.

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

<b>№</b>	<b>Зөвлөмж</b>	<b>Хэрэгжилтийн явц</b>
	108.76. Эрүүдэн шүүх болон зүй бусаар харьцсан төрийн албан хаагчийн үйлдлийг үл тэвчих, эрүүдэн шүүсэн бүх этгээдийг мөрдөн шалгах нөхцлийг бүрдүүлэх /Зүүн Тимор/	108.73–ыг үзнэ үү.
	108.77. Цагдаагийн албан хаагч эрүүдэн шүүсэн болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг нь доромжлон харьцсан байж болзошгүй үйлдлийг мөрдөн шалгах бие даасан тогтолцоог бий болгож, төрийн албан хаагч ийм төрлийн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх /Швейцари/	108.73–ыг үзнэ үү.
	108.78. Эрүүдэн шүүсэн болон зүй бусаар харьцсан байж болзошгүй талаарх бүх гомдол, мэдээллийг бие даасан агентлаг бүрэн гүйцэд мөрдөн шалгадаг байх, тухайн үйлдлийг үйлдсэн этгээд хариуцлага хүлээдэг байх, түүнчлэн мөрдөн шалгалтыг зохих эрх мэдэлтэй, хараат бус болон сэжиглэгдэж буй этгээд, тэдгээрийн ажилладаг байгууллагад хамааралгүй бие даасан этгээд хийх нөхцлийг бүрдүүлэх /Швед/	108.73–ыг үзнэ үү.
	108.79. Төрийн албан хаагч эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх үүднээс үйлдсэн байж болзошгүй бүх хэргийг нэн даруй, бүрэн гүйцэд шалгах нөхцлийг хангах арга хэмжээг эрчимжүүлэх /Итали/	Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Улсын Ерөнхий Прокурорын энэ оны 06 дугаар сарын 27–ны өдрийн А/57 дугаар тушаалаар “Мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлага”–ыг баталж, цагдаагийн байгууллага хэрэгжүүлэн ажиллаж байна. Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад дээрхи журмын дагуу мэдүүлэг авах тусгайлан бэлдсэн өрөө, уулзалт мэдүүлгийн өрөө, насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах өрөөнүүдийг бэлтгэн прокуророос

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
		<p>тусгай зөвшөөрөл гаргуулах тухай ажлын чиглэл хүргүүлж ажилласнаар нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын хэмжээнд нийт 168 өрөөнд тусгай зөвшөөрөл гаргуулан авч, 25 өрөөнд тусгай зөвшөөрөл гаргуулахаар төсөв, зардлыг шийдвэрлэж, холбогдох засвар, тохижилтын ажил хийгдэж байна.</p> <p>Мөн төсвийн тодотголоор 650,2 сая төгрөгийг батлуулж, төв, орон нутгийн цагдаагийн 82 байгууллагад тус бүр 7,930 сая төгрөгийн зардлаар нийт 82 өрөөг тохижуулах ажлыг эхлүүлээд байна.</p>
108.80.	<p>Эрүүдэн шүүх, зүй бусаар харьцахыг устгах арга хэмжээг үргэлжлүүлэх, түүний дотор хууль сахиулах албан тушаалтнуудыг сургах, боловсрол олгох /Коста Рика/</p>	<p>108.71, 108.80–ыг үзнэ үү.</p>
108.82.	<p>Хоригдож буй хүмүүстэй харьцах нөхцөлийг сайжруулахад чиглэсэн зохих алхмыг авч хэрэгжүүлэх /Япон/</p>	<p><u>1. Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд:</u> Шинэ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 235.6–д “хорих анги, алба хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хаягласан захидлын агуулга, тоо хэмжээнд хяналт тавихгүй бөгөөд хорих ангийн захиргаа захидлыг 3 өдрийн дотор илгээнэ.” гэсэн зохицуулалт шинээр тусгасан. 2002 онд батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хоригдол 10 эрх эдлэхээр заасан бол 2017 оны 07 дугаар сарын 01–ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хоригдлын 15 эрхийг хуульчилсан.</p> <p><u>2. Ахуй, нөхцөлийг сайжруулах чиглэлээр:</u> Хүний жам ёсны эрхийг хангахад чиглэсэн идэвхтэй үйл ажиллагааны үр дүнд улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 26 цагдан хорих байрнаас 18 цагдан хорих байрыг шинээр барьж, 7 цагдан хорих байрыг шаардлагад нийцүүлэн засварласан. Сүүлийн 3 жилд буюу 2015 онд 6, 2016 онд 4, 2017 онд 1, нийт 11 цагдан хорих байрны барилгыг шинээр барьж ашиглалтад оруулав. 2018 онд Өвөрхангай аймаг дахь цагдан хорих байрыг ашиглалтад оруулахаар ажиллаж байна.</p>



**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

<b>№</b>	<b>Зөвлөмж</b>	<b>Хэрэгжилтийн явц</b>
108.82.	Хоригдож буй хүмүүстэй харьцах нөхцөлийг сайжруулахад чиглэсэн зохих алхмыг авч хэрэгжүүлэх /Япон/	<p>Шинээр баригдсан болон засвар, тохижилт хийгдсэн цагдан хорих байрууд НҮБ–аас баталсан “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”–ийн 9 дүгээр зүйлд заасан хорих өрөө, тасалгаанд тавигдах үндсэн шаардлагыг бүрэн хангаж байна.</p> <p>“Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль”–д зааснаар 1 хүнд ноогдох талбайн хэмжээ 2.5 м/кв байхаас шинээр ашиглалтад орсон хорих өрөөний талбайн хэмжээ дунджаар 3–3.5 м/кв болж нэмэгдэн, байгалийн гэрэл чөлөөтэй тусах, агаарын солилцоо бүрэн хийгдэх нөхцөлийг хангаад байна. Түүнчлэн 2016 онд Нэгдсэн эмнэлэг, 2017 онд Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Баянзүрх дүүрэг дэх 409 дүгээр хорих ангийн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулсан.</p> <p>Хорих ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, хоригдлын жам ёсны эрхийг хангах, алба хаагчдын ажлын ачааллыг бууруулах зорилгоор “Хорих байгууллагын харуул хамгаалалтын стандарт”–ын дагуу 17 хорих ангийн хоригдлын байранд засвар тохижилт хийн, хорих өрөөний гэрэлтүүлэг, агааржуулалт, чийгшил, нэг хоригдолд ногдох талбайг хууль журамд нийцүүлэн, нийтийн хоол, сургалтын танхим, номын сан зэргийг тохижууллаа.</p> <p>“Сэжигтэн, яллагдагч, ялтны хоолны үйлдвэрлэл, үйлчилгээний үлгэрчилсэн загвар”–ыг батлан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, хоолны нэр төрлийг нэмэгдүүлж, эмчилгээний болон цагаан хоолыг хоригдогчдын эрүүл мэнд, хувь хүний сонирхлыг хүндэтгэн олгодог болсноор НҮБ–аас батлан гаргасан “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд”–ийн 20 дугаар зүйлд заасныг бүрэн биелүүлэн ажиллаж байна.</p>
108.83.	Хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хууль тогтоомж батлах /Зүүн Тимор/	<p>Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийг 2016 онд тус тус батлан хэрэгжүүлж байна. Мөн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийгмийн халамжийн тухай хуульд хохирогчид үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээний талаар,</p>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.83. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хууль тогтоомж батлах /Зүүн Тимор/</p>	<p>Бага, дунд боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд сургалтын агуулга, хөтөлбөрөөр дамжуулан харилцааны бусад хэлбэрээс хүчирхийллийг ялган таних, зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх үр чадвар олгох үүргийг боловсролын байгууллагад хүлээлгэх, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд энэ чиглэлээр гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг зохицуулах Зөвлөлийн чиг үүргийг тодруулж холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулсан.</p>
	<p>108.84. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээрх идэвхитэй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх /Беларус/</p>	<p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр батлагдаж, 2017 оны 02 дугаар сарын 01-ны өдрөөс мөрдөгдөж эхэлсэн. Уг хуулийг дагаж гарах 33 журмаас 31 журам батлагдан хэрэгжиж байна. Тухайлбал, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайд нарын хамтарсан тушаалаар гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам, Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журам, Хохирогчид үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журам, хүчирхийлэгчийн зан үйл нөлөөлөх сайн дурын сургалтын хөтөлбөр, журам г.м.</p> <p>Дээрх хуулиар гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээ болох нөхөн сэргээх, аюулгүй байдлыг хангах, эрх зүйн туслалцааг өргөжүүлэх, сайжруулах, үйлчилгээ үзүүлэх алба хаагчдийг сургах, давтан сургах арга хэмжээг үндэсний, бүсийн, аймаг, дүүргийн түвшинд шатлалсан аргачлалаар зохион байгуулж байна.</p> <p>Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлын хангах хамгаалах байр 2017 оны байдлаар улсын хэмжээнд Түр хамгаалах байр 15, Нэг цэгийн үйлчилгээний төв 9 байсан. Уг хамгаалах байр болон нэг цэгийн төвийн тоог нэмэгдүүлэх, хохирогчид шаардлагатай тусламж, үйлчилгээг нэг дор үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2018 оноос шинээр 10 Нэг цэгийн үйлчилгээний төвийг байгуулахаар төлөвлөж байна.</p>

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.84. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээрх идэвхитэй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх /Беларус/</p>	<p>Хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын алба хаагчдад “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох” агуулга бүхий сургалтыг тасралтгүй зохион байгуулахаас гадна Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн сургалтын хөтөлбөрт дээрх агуулга бүхий хичээлийг заавал үзэх хичээлээр тусгав.</p> <p>Олон нийтийн дундах мэдлэг ойлголтыг дээшлүүлэх ажлыг шат дараатай зохион байгуулж байна. Телевиз, мэдээ, мэдээллийн цахим хуудсаар дамжуулан зорилтот нэвтрүүлэг, сурталчилгааны ажил, олон нийтийн сүлжээнд хүчирхийллийг үл тэвчих аян өрнүүлсэн. Жишээлбэл, 1) 2017 оны 11 дүгээр сард “Хайрла-Хамгаал” үндэсний цахим аяныг улсын хэмжээнд зохион байгуулж Гэр бүлийн хүчирхийллийн урьдчилан сэргийлэх, таслан зогсоох агуулга бүхий видео сурталчилгааг олны танил хүмүүсийг оролцуулан бэлтгэж өөрийн цахим хуудсанд байршуулсан нь 65149 цахим сүлжээний хэрэглэгч нарт хүрсэн байсан. 2) Их, дээд сургуулийн оюутнуудын дунд “Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, хүүхдийг хамгаалахад оюутан залуучуудын оролцоо” сэдэвт мэтгэлцээн зохион байгуулж 48 их, дээд сургуулийн 96 мэтгэлцээний баг оролцов.</p>
	<p>108.85. Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох хүчин чармайлтаа улам идэвхижүүлэх /Филиппин/</p>	<p>108.84–өөс үзнэ үү.</p>
	<p>108.86. Гэр бүлийн болон жендэрт суурилсан хүчирхийлэл, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг халах чиглэлээр илүү хүчин чармайлт гаргах, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэх замаар нийгмийн бүх салбарт эмэгтэйчүүдийн төлөөллийг илүүтэй баталгаажуулах /БНСУ/</p>	<p>108.84–өөс үзнэ үү.</p>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.87. Гэрлэлтийн хүчин, бэлгийн дарамтыг эрүүгийн хэрэгт тооцох, хохирогчийн шүүхэд хандах, туслалцаа болон хамгаалалт авах эрхийг баталгаажуулах, ийм төрлийн хэргийг зохих ёсоор мөрдөн шалгах, гэмт этгээдэд ял шийтгэлийг хуулийн дагуу заавал хүлээлгэх замаар жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хүчин чармайлтаа бэхжүүлэх /Словени/</p>	<p>Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлд заасны дагуу “хүчиндэх” үйлдэл бүхэлдээ эрүүгийн гэмт хэрэгт хамаарах ба мөн зүйлийн 2.3 дахь заалтад заасны дагуу “гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг” хүчиндсэн, бэлгийн шинжтэй аливаа үйлдэл хийхийг шаардсан тохиолдолд “хүчиндэх” гэмт хэрэгт хамаарахаар заасан.</p>
	<p>108.88. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх ажлыг дэмжих эмэгтэйчүүдийн эсрэг бүх төрлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд чиглэсэн үндэсний стратеги баталж, үр нөлөөтэй хэрэгжүүлэх /Турк/</p>	<p>Эмэгтэйчүүдийн эсрэг бүх төрлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогч эмэгтэйчүүдийн аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэл дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хүчирхийлэгчийн зан үйл нөлөөлөх сургалтын сайн дурын хөтөлбөр, журмыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайд нарын хамтарсан тушаалаар, албадан сургалтын хөтөлбөр, журмыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар тус тус батлуулан, хэрэгжүүлж байна.</p> <p>Мөн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх стратегийг шинэчлэх зорилгоор Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код-326/-д нэмэлт өөрчлөлт орууллаа. Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагатай байгуулсан санамж бичгийн хүрээнд гэр бүлийн хүчирхийллийн чиглэлээр сургагч багш бэлтгэх сургалтад нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын 70 алба хаагчийг хамруулсан. Мөн НҮБ-ын Хүн амын сан, Швейцарын хөгжлийн агентлагын дэмжлэгтэй хэрэгжүүлж байгаа “Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийн системийг боловсронгуй болгох чиглэлээр салбар хоорондын зохицуулалт, чадавхийг бэхжүүлэх” зөвлөлдөх уулзалтыг төрийн болон төрийн бус байгууллагын 30 төлөөлөлтэйгээр хийв.</p>

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.88. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх ажлыг дэмжих эмэгтэйчүүдийн эсрэг бүх төрлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд чиглэсэн үндэсний стратеги баталж, үр нөлөөтэй хэрэгжүүлэх /Турк/</p>	<p>Хууль, журмын хэрэгжилтийг хангах, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, нутаг дэвсгэрийн хүн амын нягтаршил, гэмт хэрэг, захиргааны зөрчлийн гаралтыг харгалзан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах талаар төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэст 12 заалт бүхий зөвлөмж хүргүүлэн үр дүнг тооцон ажиллаж байна. Түүнчлэн “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх, сурталчлах нэг сарын аян”-ныг 2017– 02–10–ны өдрөөс 03 дугаар сарын 12–ны хооронд улсын хэмжээнд зохион байгуулж, биелэлт, үр дүнг тооцож ажиллалаа. Аяны хугацаанд нийт 14 ажил, арга хэмжээ төлөвлөснөөс Урьдчилан сэргийлэх хэлтэс 6, тус хэлтэс нь Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэс, Мэдээлэл, технологи, холбооны газартай хамтран хэрэгжүүлэх 2, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс 6 ажил, арга хэмжээг хийж гүйцэтгэхээс Урьдчилан сэргийлэх хэлтэс 73, Нийслэлийн цагдаагийн газар 72, аймгууд 38.8, улсын хэмжээнд 61.2 хувьтай дүгнэгдсэн.</p>
	<p>108.89. Гэр бүлийн хүчирхийллийг даван туулагсдын хамгаалалтыг улам сайжруулах, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, түүний шалтгаан, үр дагаврын асуудлаар Тусгай илтгэгчийг Монгол Улсад урих /АНУ/</p>	<p>Судалж байна.</p>
	<p>108.90. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээрх хүчин чармайлтаа үргэлжлүүлэх /Латви/</p>	<p>108.84–өөс үзнэ үү.</p>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.91. Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, мөрдөн шалгах тогтолцоог бэхжүүлэх, энэ төрлийн хэргээр ажилладаг хууль сахиулагчдыг сургах /Молдав/</p>	<p>Хууль зүй, дотоод хэргийн яам, Олон улсын эрх зүйн байгууллагатай хамтран 2016 оноос эхлэн “Монгол Улс дахь жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх: хууль зүйн салбарын чадавхийг бэхжүүлэх” төсөл хэрэгжүүлж байна. Уг төслийн хүрээнд “Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тэмцэхэд хууль зүйн салбарын чадавхи, уялдаа холбоог бэхжүүлэх сургалт”-ыг заах сургагч багш бэлтгэн, гарын авлага боловсруулан хэвлүүлж 10 аймгийн 500 гаран хууль 500 шүүгч, прокурор, цагдаагийн алба хаагч, өмгөөлөгчийг сургаад байна.</p>
	<p>108.92. Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг одоогийн хуулиа үр нөлөөтэй хэрэгжүүлэх, алслагдсан газруудад хамгаалалтын байр барих зэргээр хохирогчдыг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээгээ бэхжүүлэх /Швейцари/</p>	<p>2017 оны байдлаар улсын хэмжээнд Түр хамгаалах байр 16, Нэг цэгийн үйлчилгээний төв 9 ажиллаж байгаа бөгөөд эдгээрийн байрны үйл ажиллагааны зардалд орон нутгаас нийт 230 гаран сая төгрөгийг санхүүжүүлжээ. 2018 оноос шинээр Баян-Өлгий, Дархан-Уул, Дорнод, Өвөрхангай, Өмнөговь, Хөвсгөл, Хэнтий аймаг, 3 дүүрэгт нийт 10 Нэг цэгийн үйлчилгээний төв байгуулахаар ажиллаж байна. Орон нутаг Нэг цэгийн үйлчилгээний төвийн байрыг гаргаж олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр тохижуулна. Баян-Өлгий, Дархан-Уул аймаг дээрх төвийг байгуулахад орон нутгийн төсөвт 350 сая төгрөгийг тусгуулан, батлуулсан.</p>
	<p>108.93. Гэр бүлийн хүчирхийллийг эрүүгийн хэрэгт тооцох, хохирогчдын хамгаалалтыг сайжруулах, гэмт этгээдэд ял шийтгэл оногдуулах зорилгоор Парламентаар хэлэлцэж буй гэр бүлийн хүчирхийллийн хуулийн төслийг батлах /Австрали/</p>	<p>108.84-өөс үзнэ үү.</p>
	<p>108.94. Гэр бүлийн хүчирхийллийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдлэг ойлголтыг түгээх замаар гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх /Испани/</p>	<p>108.88-аас үзнэ үү.</p>

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

<b>№</b>	<b>Зөвлөмж</b>	<b>Хэрэгжилтийн явц</b>
108.95.	Холбогдох байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, нотлох баримтын шаардлагыг эргэж харах болон тусгаарласан шийдвэрийн хэрэгжилтийг баталгаажуулах замаар гэр бүлийн хүчирхийллийн эсрэг эрх зүйн хамгаалалтыг авахад учирч буй саад тотгорыг арилгах /Австри/	108.84, 108.91–ээс үзнэ үү.
108.96.	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үр нөлөө бүхий хамгаалалт авах, эрхээ сэргээлэх боломжийг сайжруулах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэм буруутныг яллах чадавхийг бэхжүүлэх, гэрлэлтийн хүчинг эрүүгийн хэрэгт тооцох /Чех/	108.84, 108.91–ээс үзнэ үү.
108.97.	Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, тэдний эсрэг хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд чиглэсэн одоогийн хууль тогтоомжийн үр нөлөөтэй хэрэгжилтийг баталгаажуулах /Итали/	108.84, 108.88 –ыг үзнэ үү.
108.98.	Гэр бүлийн хүчирхийллээс хамгаалалт хайж буй эмэгтэйчүүд, хүүхдүүдэд зориулсан хамгаалах байрыг илүү олноор байгуулахад анхаарах /Малайз/	108.92–ыг үзнэ үү.
108.99.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хууль тогтоомжоо улам бэхжүүлэх /ОХУ/	108.84–өөс үзнэ үү.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	108.100. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэмцэх маш тодорхой эрх зүйн орчныг бүрдүүлэх, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод зориулсан нийгмийн хамгааллын тогтолцоог бий болгох /Серби/	108.84–өөс үзнэ үү. Нийгмийн халамжийн тухай хуульд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдыг түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зохицуулалт тусгагдсан.
	108.101. Гэр бүлийн хүчирхийллийг эрүүгийн хэрэгт тооцох өөрчлөлтийг эрүүгийн хууль тогтоомждоо оруулах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэмт этгээдэд эрх бүхий байгууллагууд хариуцлага хүлээлгэн яллах нөхцлийг хангах, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үзүүлж буй бүх төрлийн үйлчилгээнд хангалттай санхүүжилт олгох /Словак/	Гэр бүлийн хүчирхийллийг Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлээр гэмт хэрэгт тооцсон. 108.84–өөс үзнэ үү.
	108.102. Гэр бүлийн хүчирхийллийг эрүүгийн хэрэгт тооцох өөрчлөлтийг эрүүгийн хууль тогтоомждоо оруулах /Испани/	108.101–ийг үзнэ үү.
	108.103. Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, гэр бүлийн хүчирхийллийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх сурталчилгааны ажлын цар хүрээг өсгөх, хохирогчдод үзүүлэх үйлчилгээ, хамгаалалтыг өргөжүүлэх /Канад/	108.84–өөс үзнэ үү.
	108.104. Гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн дарамтыг эрүүгийн хэрэгт тооцохыг анхаарах, гэмт этгээд хуулийн дагуу хариуцлага хүлээдэг болох нөхцлийг хангах /Унгар/	108.84–өөс үзнэ үү.



**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	108.105. Гэр бүлийн хүрээнд учирдаг бүх төрлийн хүчирхийлэл, заналхийлэл, бэлгийн дарамт, мөлжлөг зэргийг оролцуулан гэр бүлийн хүчирхийллийг эрүүгийн хэрэгт тооцох хууль тогтоомж батлах, гэмт этгээдийг яллан шийтгэдэг, хохирогчид, тэр дундаа орон нутагт буй хохирогчид халамж авдаг болох нөхцлийг хангах /Парагвай/	108.101, 108.84–өөс үзнэ үү.
	108.106. Эрүү шүүлтийн эсрэг хорооноос өгсөн зөвлөмжид нийцүүлэн хүүхдийн бие махбодийн шийтгэлийг эрс хориглох /Чили/	Нийгмийн орчинд хүүхдийн эсрэг бүх төрлийн хүчирхийллийг холбогдох хуулиудад бүрэн хориглосон.
	108.107. Гэр бүл дэх шийтгэлийг оролцуулан хүүхдийн бие махбодийн бүх шийтгэлийг эрс хориглох /Швед/	108.106–г үзнэ үү. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/27 дугаар тушаалаар батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, мэргэжлийн удирдлагаар хангах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд Монголын хүүхдийн эрхийн сургалт, судалгааны хүрээлэн Төрийн бус байгууллага, Монголын хүүхдийн эрхийн үндэсний төв Төрийн бус байгууллагын төлөөллийг оруулан ажил лаж байна. Хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор 4 төрийн бус байгууллагуудтай хамтран сургалт, сурталчилгааны ажилд санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх замаар хамтран ажиллаж байна.
	108.108. Хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийг мөлжлөгт автах, ялангуяа хөдөлмөрийн хортой нөхцөлд ажиллуулахаас хамгаалах үр нөлөө бүхий арга хэмжээг авах /Герман/	– Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 19–ний өдрийн “Өвөл, хаврын улирлын морины уралдааны тухай” 19 дүгээр тогтоолоор өвлийн улиралд хурдан морины уралдаан зохион байгуулах болон жил бүрийн хаврын тэргүүн сарын шинийн 1–ний өдрөөс 5 дугаар сарын 1–ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулах хурдан морины уралдаан, сунгаанд 12 хүртэлх насны хүүхдээр морь унуулахыг хориглосон.

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.108. Хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийг мөлжлөгт автах, ялангуяа хөдөлмөрийн хортой нөхцөлд ажиллуулахаас хамгаалах үр нөлөө бүхий арга хэмжээг авах /Герман/</p>	<p>– Дээрх тогтоолын дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 3 дугаар сарын 19–ний өдрийн А/71 тоот тушаалаар “Хүүхэд ажиллахыг хориглосон ажлын байрны жагсаалт”–д өөрчлөлт орсон. Мөн Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага MNS 6264:2011 стандартыг шинэчлэн Үндэсний стандартчиллын зөвлөлийн 2018 оны 5 дугаар сарын 31–ний өдрийн хурлаар батлуулсан.</p> <p>– Хурдан морь унаач хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хамгаалах хүрээнд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас тодорхой ажлууд хийж байна. Тухайлбал, хурдан морь унаач хүүхдийн гэнэтийн ослын даатгалын хураамжийн хэмжээ, нөхөн олговорын хэмжээг нэмэгдүүлэх асуудлаар даатгалын компаниудтай ажиллаж, даатгалын 1 компаниас хураамжийн хэмжээг 100,0 мянган төгрөг, нөхөн олговорын дээд хэмжээг 20,0 сая төгрөг болгох бүтээгдэхүүн гаргахаар Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл аваад байна. Түүнчлэн аймаг, нийслэлийн Засаг дарга, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Монголын морин спорт уяачдын холбоонд хурдан морины уралдаан, уяач хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах асуудлаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 06 дугаар сарын 15–ны өдрийн 1/1896 тоот албан бичгээр чиглэл хүргүүлэв.</p> <p>– Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын 138, 182 дугаар конвенцийн заалтад нийцүүлэн боловсруулсан. Ингэснээр хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах, хүүхдийн хөдөлмөрийг хориглохтой холбоотой зохицуулалтыг оруулсан. Хүүхдээр хөнгөн ажил хийх насны хязгаарыг шинээр хуульд тусгасан.</p>

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.109. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах 2012–2016 оны үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах, хөтөлбөр хэрэгжсэний дараахь тогтолцоог судлан үзэх /Итали/</p>	<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагатай хамтран Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах 2012–2016 оны үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээг хийлгэсэн. Хөтөлбөр нь “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах тухай” Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенцийн үзэл санааг үндэслэл болгон хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг хориглох, хязгаарлах, түүнтэй тэмцэх үйл ажиллагааг бүх салбарт эрчимжүүлэх замаар 2016 он гэхэд Монгол Улсад хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг бүрэн устгах зорилготой байсан бөгөөд хүүхдийн хөдөлмөрийг бүрэн устгах зорилгоо хангаж чадаагүй гэсэн дүгнэлт гаргасан. Уг хөтөлбөрийн хэрэгжилт нь хангалттай сайн байгаагүй нь хэд хэдэн шалтгаанаас үүдэлтэй гэж дүгнэсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа богино, хөтөлбөрийн зорилгыг бүрэн хэрэгжүүлэх буюу 2016 он гэхэд Монгол улсад хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг бүрэн устгах боломжгүй байсан.</li> <li>2. ХХТХ–ийг устгах үндэсний хороо, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг сайдын тушаалаар баталсан нь оролцогч талуудын оролцоог хангаж хороог идэвхтэй ажиллуулах, үйл ажиллагааны санхүүжилтыг улсын төсөвт тусгаж хэрэгжүүлэхэд хүндрэлтэй болсон.</li> <li>3. Орон тооны бус хороогоор дамжуулан хөтөлбөрийн хэрэгжилтийн зохицуулах, үйл ажиллагааг нь уялдуулахад хүндрэлтэй байсан.</li> </ol>
	<p>108.110. Хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх ажлаа өргөжүүлэх, хүүхэд хөдөлмөрийн хортой, аюултай нөхцөлд, түүний дотор бичил уурхайд хөдөлмөр эрхлэхгүй байх нөхцлийг хангах</p>	<p>– Хүүхдийн хөдөлмөр, хүчирхийллийн асуудлаар Хүүхэд хамгааллын судалгааг 2018 онд хийхээр төлөвлөж, судалгааны удирдах хороог төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын төлөөлөлтэй байгуулаад байна. Судалгааг 2018 оны 09 дүгээр сард эхлүүлэн, ондоо багтаан дуусгахаар ажиллаж байна.</p>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.110. Хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх ажлаа өргөжүүлэх, хүүхэд хөдөлмөрийн хортой, аюултай нөхцөлд, түүний дотор бичил уурхайд хөдөлмөр эрхлэхгүй байх нөхцлийг хангах</p>	<p>– Хүүхдийн эрхийг хангах асуудлаар салбар дундын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах хүрээнд яам, агентлаг, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайдаар ахлуулсан, байнгын ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны өдрийн А/218 тоот тушаалаар байгуулан хамтран ажиллаж байна. Тус ажлын хэсгийн төлөвлөгөөний 9–т “Уул уурхай, олборлолт, барилга, аялал жуулчлал, ойн болон хөдөө аж ахуй, газар тариалан, боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудтай тухайн асуудлыг хариуцсан яам, агентлагаас байгуулах гэрээ, тусгай зөвшөөрөл олгох журамд “Хүүхэд ажиллахыг хориглосон ажлын байрны жагсаалт”–ыг мөрдөж ажиллах талаар тусгаж, иргэдийн оролцоо, хяналтыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах” асуудлыг тусган Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Барилга хот байгуулалтын яам тус тус хэрэгжилтийг хариуцаж ажиллаж байна.</p> <p>– Хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн ажлын орчинд эрсдлийн үнэлгээ хийх аргачлал боловсруулах ажлыг Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран 2018 оны 8 дугаар сард эхлүүлэхээр ажиллаж байна.</p> <p>–”Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”–ын хэрэгжилтэд хяналт тавих тухай Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2018 оны 01/16, 01/174, 1/131 албан тоотоор 3 удаагийн дараах чиглэл, зөвлөмж хүргүүлсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг олон нийтэд сурталчлах, жагсаалтын дагуу аймаг, нийслэлийн Мэргэжлийн хяналтын байгууллага, Цагдаагийн байгууллага, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, хэлтэс, Боловсрол, соёл, урлагийн газар, төрийн бус</li> </ul>

<b>№</b>	<b>Зөвлөмж</b>	<b>Хэрэгжилтийн явц</b>
	<p>108.110. Хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх ажлаа өргөжүүлэх, хүүхэд хөдөлмөрийн хортой, аюултай нөхцөлд, түүний дотор бичил уурхайд хөдөлмөр эрхлэхгүй байх нөхцлийг хангах</p>	<p>байгууллагатай хамтарсан хяналт шалгалт зохион байгуулж, хөдөлмөр эрхэлж буй хүүхдийг илрүүлэх, жагсаалтаар хориглосон ажлын байр, салбарт 18 хүртэлх насны хүүхэд хөдөлмөр эрхэлж буй нь илэрсэн, тогтоогдсон тохиолдолд холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авах үйл ажиллагааг зохион байгуулах;</p> <ul style="list-style-type: none"> <li>• Бичил уурхайтай аймгууд орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудтай хамтран хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах, зөрчлийг арилгах арга хэмжээ авах;</li> <li>• Бичил уурхай дээр ажиллаж буй гэр бүл, айлд мал маллаж байгаа гэр бүл, хөлсөөр хурдан морь унаж байгаа хүүхэд, тэдний гэр бүлд чиглэсэн сургалт, зөвлөгөөн, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулж, мэдлэгжүүлэх;</li> <li>• Орон нутгийн хувийн хэвшлийн байгууллагуудад “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг сурталчлан таниулж, мөрдүүлэх, гэрээнд тусгах ажлыг зохион байгуулах;</li> <li>• Хурдан морины уралдаанч хүүхэд, хөдөлмөр эрхлэгч хүүхдийн мэдээллийг шинэчлэн нэгтгэж, үр дүнг тайлагнах;</li> <li>• Хурдан морины уралдааны бүртгэл мэдээллийг сайжруулах, уралдааны үед хүүхдийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд Хамтарсан багийг татан оролцуулах, чиглэл хүргүүлэх, арга зүйгээр хангах ажиллах;</li> <li>• Аймаг, орон нутгийн түвшинд 3 талт буюу төр, иргэн, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтарсан зөвлөгөөн зохион байгуулж, хүүхдийн хөдөлмөрийн хяналтыг сайжруулах, бууруулах үйл ажиллагаа зохион байгуулах.</li> </ul>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.111. Хүүхдийг хөдөлмөр эрхлүүлсэн ажил олгогчдод хариуцлага хүлээлгэх зэргээр хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх ажлаа үргэлжлүүлэх, гэр бүлд болон сургуульд хүүхдэд хүлээлгэх хүчирхийллийн бус сахилга батын шинэ хэлбэрүүдийг нэвтрүүлэх /Литва/</p>	<p>Одоогийн Хөдөлмөрийн тухай хуулийн 141.1.6–д “насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажил гүйцэтгүүлсэн, зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү хүнд ачааг өргүүлсэн, зөөлгөсөн, насанд хүрээгүй хүнийг хэвийн бус нөхцөлтэй болон түүний оюун ухааны хөгжил, эрүүл мэндэд нь харшлах ажлын байранд, эсхүл амралтын өдөр, шөнө буюу илүү цагаар ажиллуулсан, ажилтныг энэ хуулийн 74 дүгээр зүйлийн заалтыг зөрчиж илүү цагаар ажиллуулсан албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, эсхүл түүнийг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр хөдөлмөрийн улсын байцаагч буюу шүүгч торгох” гэж заасан байдаг. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тус торгуулийн хэмжээг нэмэгдүүлэн хууль зөрчсөн албан тушаалтныг 1,5 саяас 2 сая төгрөг хүртэл, аж ахуйн нэгж байгууллагыг 3,8 сая хүртэл төгрөгөөр торгохоор тусгасан.</p>
	<p>108.112. Хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх стратегиудыг судлан тодорхойлох /Норвеги/</p>	<p>– Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөр 2016 онд хэрэгжиж дууссан.</p> <p>– Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр /2017–2021 он/ Засгийн газрын 2017 оны 270 тоот тогтоолоор баталсан. Тус хөтөлбөрт хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг тусгайлсан үйл ажиллагааны чиглэл болгож, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон. Тухайлбал:</p> <p>Хөтөлбөрийн 3.4.3–т “Хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, зан суртахуунд сөргөөр нөлөөлөх хөдөлмөрийг хориглох” чиглэлээр дараах үйл ажиллагаа туссан.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээрт “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”–ыг мөрдүүлэх асуудлыг тусгаж, хэрэгжүүлэх;</li> <li>2. Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийг устгах чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;</li> <li>3. Хурдан морины өвөл, хаврын уралдаанд 16–аас доош насны хүүхэд оролцохыг хориглох, зөвшөөрөгдсөн уралдааны үед хүүхдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах асуудлыг хуульчлах;</li> </ol>

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

<b>№</b>	<b>Зөвлөмж</b>	<b>Хэрэгжилтийн явц</b>
	108.113. Хүүхдийн хөдөлмөрийг мөлжиж буй ажил олгогчдын үйлдлийг эрүүгийн хэрэгт тооцох, тэдэнд хариуцлага хүлээлгэх зэргээр хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх /Польш/	Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай ОУХБ-ын 182 дугаар конвенцийн 3 дугаар зүйлд “хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр” гэдэгт: (a) боолчлолын бүх хэлбэр болон хүүхдийг худалдах, дамжуулан худалдах, өрийн төлөөс, хамжлагын албат болгох, хүчээр буюу албадан хөдөлмөрлүүлэх, түүний дотор зэвсэгт мөргөлдөөнд ашиглах зорилгоор хүчээр буюу албадан оролцуулах зэрэг боолчлолтой төстэй дараахь үйл ажиллагаа хамаарна: (b) хүүхдийг биеэ үнэлэх, садар самуун сурталчилгааны үйлдвэрлэл буюу садар самуун үзүүлбэрт ашиглах, зуучлах, санал болгох; (c) олон улсын холбогдох гэрээнд тодорхойлсноор хүүхдийг мансууруулах бодис үйлдвэрлэх, хил дамжуулан худалдах зэрэг хууль бус үйл ажиллагаанд ашиглах, зуучлах, санал болгох; (d) ажлын шинж чанар, түүнийг гүйцэтгэх нөхцөл нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх ажил гэж үзэхээр уг конвенцийн зорилгод нийцүүлэн тусгажээ. Шинэ Эрүүгийн хуульд эдгээр үйлдлүүдийг бүгдийг гэмт хэрэгт тооцсон ба ингэхдээ үйлдлийн шинж чанараас хамаарч хэд хэдэн тусдаа гэмт хэрэг байхаар тусгасан.
	108.114. Хүүхдүүд бүх төрлийн хүчирхийлэл, мөлжлөгөөс, ялангуяа хөдөлмөрийн хортой нөхцөл дэх хүүхдийн хөдөлмөрийн хэлбэрээс хамгаалагдсан байх нөхцлийг баталгаажуулах хүчин чармайлтаа үргэлжлүүлэх /БНСУ/	108.110, 108.113–ыг үзнэ үү.
	108.115. Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хүчин чармайлтаа үргэлжлүүлэх /Морокко/	108.24–ийг үзнэ үү.

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.116. Хууль сахиулах байгууллагын хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, гэмт этгээдийг яллах чадавхийг бэхжүүлэх, хохирогчдод үзүүлэх үйлчилгээг өргөжүүлэх замаар Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах /Канад/</p>	<p>Засгийн газрын 2016–2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт мөнгө угаах, хүний наймаа, хар тамхи болон цахим гэмт хэрэг зэрэг шинэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ гэж тусгасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх” үндэсний хөтөлбөрийг боловсруулан Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолоор батлуулсан. Мөн онд хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг Хууль зүй, дотоод хэргийн дэд сайдаар ахлуулан байгуулж хуулийн хэрэгжилтийг сайжруулах ажлыг зохион байгуулж байна. Шүүх эрх мэдлийн болон цагдаа прокурорын байгууллагын ажилтан албан хаагчдыг энэ төрлийн гэмт хэргийг хянан шийдвэрлэх, яллах чадавхийг бэхжүүлэх чиглэлээр мэргэшүүлэх, хил хамгаалах, гадаадын иргэн, харьяатын байгууллагын албан хаагчдыг энэ төрлийн гэмт хэрэг, хохирогчийг илрүүлэх чиглэлээр Азийн сантай хамтран хэрэгжүүлж буй “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хэрэг хянан шалгах ажиллагаа: албан хаагчдыг чадавхижуулах нь” төслийн хүрээнд шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын 200 ажилтан албан хаагчдыг сургалтад хамруулахаар төлөвлөн сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн байгууллагуудаас 40 сургагч багш бэлтгэсэн. Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Хүн худалдаалахтай тэмцэхэд Хятад Монголын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Хятад, Монгол 2 улсын төв болон хилийн боомтуудад үйл ажиллагаа явуулдаг цагдаа, гадаадын иргэн, харьяат, хил хамгаалах байгууллагын албан хаагчдаас гадна консулын газрын ажилтнуудад адилхан агуулга бүхий сургалтыг зохион байгуулж төслийн эцэст хамтарсан сургалтыг зохион байгуулж байна. Одоогийн байдлаар цагдаа, гадаадын иргэн,</p>



**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.116. Хууль сахиулах байгууллагын хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, гэмт этгээдийг яллах чадавхийг бэхжүүлэх, хохирогчдод үзүүлэх үйлчилгээг өргөжүүлэх замаар Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах /Канад/</p>	<p>харьяат болон консулын газрын нийт 120 ажилтан албан хаагчдад сургалтыг зохион байгуулаад байна. Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасны дагуу хүн худалдаалахын хохирогчдыг мэргэжлийн сургалтад хамруулах, ажлын байраар хангах, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болсон гадаадын иргэдэд туслалцаа үзүүлэх ажлуудыг зохион байгуулж байна. Мөн хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын хүн худалдаалах гэмт хэргийн талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх төв, тусгай утас ажиллуулах ажилд нь улсын төсвөөс 22.000.000 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулж байна. –ЦЕГ–ын даргын 2017 оны Б/284 дүгээр тушаалаар Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийг “Зохион байгуулалттай гэмт бүлэг, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс” болгон өөрчилж, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тасгийг 5 алба хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр тус хэлтэст шинээр байгуулсан.</p>
	<p>108.117. Хүн худалдаалахтай тэмцэх тухай 2012 оны хуулийг хэрэгжүүлж, гэмт этгээдийг мөрдөн шалгах, яллах ажиллагааны үр нөлөөтэй байдлыг хангах, хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх үүднээс хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагыг бэхжүүлэх /Бразил/</p>	<p>108.116–аас үзнэ үү.</p>
	<p>108.118. Хүн худалдаалахын эсрэг маш хатуу хууль батлах замаар хүүхдийг худалдаалах бүх хэлбэрийг эрүүгийн хэрэгт тооцох /Сиерра Леон/</p>	<p>Эрүүгийн шинэ хуулийн 16.6 дугаар зүйлд Хүүхэд худалдаалах, 13.1 дүгээр зүйлд Хүн худалдаалах гэмт хэргийг тусгасан. Хүн худалдаалах гэмт хэрэгт ялын хэмжээг 2 жилээс бүх насаар нь хорих, хүүхэд худалдаалах гэмт хэрэгт ялын хэмжээг 13.1 дүгээр зүйлд заасан шинжгүй бол 2–8 жил хорихоор тусгасан байна.</p>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.119. Хүн худалдаалах бүх хэрэгт шаардлагатай мөрдөн шалгах, яллах ажиллагаа явуулах замаар хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдийг худалдаалахтай тэмцэх арга хэмжээгээ өргөжүүлэх /Малайз/</p>	<p>108.116–аас үзнэ үү.</p>
	<p>108.120. Хүн худалдаалахтай тэмцэхэд шаардлагатай боловсон хүчний болон материаллаг бүх нөөцийг хуваарилан олгох /Гондурас/</p>	<p>Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг Монгол Улсад Гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэд Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх Дэд зөвлөл хариуцдаг. Уг зөвлөлийг Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд даргалдаг бөгөөд төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын төлөөлөл 25 гишүүн, 2 нарийн бичгийн даргатай. Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албанд “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тасаг”–2015 онд 2 эрүүгийн төлөөлөгчтэй ажиллаж байсан бол, 2017 онд 1 дарга, 4 эрүүгийн төлөөлөгчийн орон тоотойгоор ажиллаж байна.</p>
	<p>108.121. Хүн худалдаалах хэргийн хохирогч, гэрч эрх зүйн туслалцаа, хамгаалалт, нөхөн сэргээх үйлчилгээ авах боломжоор баталгаатай хангагдах нөхцлийг бүрдүүлэхэд шаардлагатай төсвийн, захиргааны болон эрх зүйн арга хэмжээнүүдийг авах /Мексик/</p>	<p>Засгийн газрын 2016 оны 07 дугаар сарын 27–ны өдрийн 4 дүгээр тогтоолоор Тахарын ерөнхий газрыг татан буулгаж, зарим чиг үүргийг цагдаагийн байгууллагад шилжүүлсэнтэй холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны 08 дугаар сарын 11–ний өдрийн 444 дүгээр тушаалаар цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтцэд Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийг байгуулан ажиллаж байна. Цагдаагийн байгууллагаас 2016, 2017 онд нийт 55 хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлснээс урьдчилан сануулах 24, тодорхой үйлдлийг хязгаарлах 2, биечилсэн хамгаалалт 15, тусгай техник, хэрэгслээр хангах 7, аюулгүй газарт түр байрлуулах 7 хамгаалалт хийгдсэн байна. Төлбөрийн чадваргүй хохирогчид хууль зүйн /өмгөөллийн/ туслалцаа үзүүлэх ажлын хүрээнд Хуульчдын холбоо, Хууль зүйн үндэсний хүрээлэн, аймгуудын Хууль зүйн туслалцааны төвтэй хамтран улсын хэмжээнд 403 гэрч, хохирогчид үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ, 223 гэрч хохирогчид сэтгэл зүйн туслалцаа, зөвлөгөө үзүүлэх ажлыг зохион байгууллаа.</p>

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

<b>№</b>	<b>Зөвлөмж</b>	<b>Хэрэгжилтийн явц</b>
	<p>108.121. Хүн худалдаалах хэргийн хохирогч, гэрч эрх зүйн туслалцаа, хамгаалалт, нөхөн сэргээх үйлчилгээ авах боломжоор баталгаатай хангагдах нөхцлийг бүрдүүлэхэд шаардлагатай төсвийн, захиргааны болон эрх зүйн арга хэмжээнүүдийг авах /Мексик/</p>	<p>Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд олон нийтийн оролцоо дэмжлэгийг авах, тэдэнд үйл ажиллагаагаа танилцуулах зорилгоор иргэд, олон нийтэд 13 удаагийн мэдээлэл сурталчилгаа, сургалтын арга хэмжээг зохион байгуулан ажиллаж гэрч хохирогчийг хамгаалах асуудал холбогдох хуульд заасны дагуу зохих ёсоор явагдаж байна.</p> <p>Монгол Улсад хүн худалдаалахын хохирогчдыг хамгаалах үйлчилгээг тухайлбал эрх зүйн туслалцаа, хамгаалалт, богино болон урт хугацаагаар нөхөн сэргээх үйлчилгээ төрийн бус байгууллагуудаар дамжуулан үзүүлж байна. Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудад төрөөс 2017 онд дараах санхүүжилтийг олгоод байна. Үүнд:</p> <p>Хүн худалдаалахтай тэмцэх хууль тогтоомжийн талаар иргэд олон нийт оюутан, сурагчдад мэдлэг олгох чиглэлээр Эмэгтэйчүүд, гэр бүлийн сэтгэлзүйн боловсролын төв төрийн бус байгууллагад 8.090.000 төгрөгийн санхүүжилт олгон нийт 800 хүнд хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх мэдлэг, ойлголт олгосон.</p> <p>ЭКПАТ Монгол сүлжээ төрийн бус байгууллагын “Үе тэнгийнхэн үе тэнгийнхэндээ” төслийг 8.000.800 төгрөгөөр санхүүжүүлсэн. Төслийн хүрээнд 150 үе тэнгийн сургагч бэлтгэн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 1.000 сурагчдад хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажил хийсэн.</p>
	<p>108.122. Хүн худалдаалахын эсрэг хөтөлбөрт шаардлагатай боловсон хүчний болон бусад нөөцийг хангалттай байдлаар үргэлжлүүлэн олгох /Филиппин/</p>	<p>2017 оны Засгийн газрын тогтоолоор “Хүн худалдаалахтай тэмцэх тухай үндэсний хөтөлбөр”-ийг 4 жилийн хугацаатай баталсан. Бусад нөөцийг хангалттай байдлаар үргэлжлүүлэн олгож байгаа. Монгол Улсын засгийн газраас баталсан Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд</p>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.122. Хүн худалдаалахын эсрэг хөтөлбөрт шаардлагатай боловсон хүчний болон бусад нөөцийг хангалттай байдлаар үргэлжлүүлэн олгох /Филиппин/</p>	<p>улсын төсвөөс 2018 онд 709 сая төгрөг баталсан. Уг батлагдсан төсвийн 97 сая төгрөгөөр хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 8 төрийн бус байгууллагын үйл ажиллагааг санхүүжүүлнэ. Уг санхүүжилтээр:</p> <ul style="list-style-type: none"> <li>–хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тодорхойлох криминологийн судалгаа, энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдын талаар судалгаа,</li> <li>–хөдөлмөрийн мөлжлөгийн талаар тандалт судалгаа хийж, судалгааны үр дүнд суурилсан олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх ажилд зөвлөгөө өгөх,</li> <li>–хүн худалдаалах гэмт хэргийн мэдээллийн сан үүсгэн, мэдээллийг хүлээн авч боловсруулах, цахим хуудас бүтээх,</li> <li>–хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх агуулга бүхий цуврал нэвтрүүлэг, богино хэмжээний видео сурталчилгаа бэлтгэн олон нийтэд хүргэх,</li> <li>–аж ахуйн нэгжийн ажилтнуудад хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалт, бэлгийн мөлжлөгийн хохирогчдод хууль зүйн зөвлөгөө өгөхөд өмгөөлөгчдийг чадавхижуулах сургалт зохион байгуулах, хохирогчдод туслалцаа үзүүлэх гарын авлага боловсруулан хэвлүүлэх,</li> <li>–хүүхэд залуучуудын дунд хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр шинэлэг хэлбэрийн сургалт, сурталчилгааны ажил болон “Хөх зүрхний аян” зохион байгуулах,</li> <li>–орон нутгийн нийтийн тээврийн /галт тэрэг/ зорчигчдод хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх агуулга бүхий нэвтрүүлэг, видео сурталчилгааг түгээх,</li> <li>–хүн худалдаалах гэмт хэргийн талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх төв, тусгай утас ажиллуулах, сурталчлах ажлыг зохион байгуулах зэрэг ажлуудыг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлнэ.</li> </ul>

ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.123. Эрх зүйн шинэ орчин буюу Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд заасны дагуу хүн худалдаалах үйлдэлд ял оногдуулах, хууль сахиулах албан хаагчдын үйлдсэн хэргийг оролцуулан хүн худалдаалах хэрэг үйлдсэн байж болзошгүй бүх үйлдлийг мөрдөн шалгах, хохирогчдод нөхөн төлбөр олгох, нөхөн сэргээх зохицуулалтыг хэрэгжүүлэх зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй бүх талд зориулсан сургалт зохион байгуулах /Мексик/</p>	<p>Мөн Монгол Улс хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг 2012 онд баталж, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх конвенцийн Хүн ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай Палермогийн протоколд нийцүүлэн хүн худалдаалах гэмт хэргийг тодорхойлсон. Шинэ Эрүүгийн хуульд Хүн худалдаалах гэмт хэргийг тусгайлан бүлэг болгож тусгаад байна. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг дэмжих зорилгоор Гадаад харилцааны сайд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх асуудал эрхэлсэн Шведийн Тусгай үүрэг гүйцэтгэгч Элчин сайд н.Пер-Андерс Сунэссоныг Монгол Улсад урьсан. Элчин сайд 5 дугаар сарын 28-наас 6 дугаар сарын 1-ний өдөр Монгол Улсад айлчилсан бөгөөд энэ үеэр хоёр тал иргэд консулын чиглэлээр хамтран ажиллах, байнгын зөвлөлдөх механизм байгуулах боломжийг судлах, хохирогч илрүүлэх, хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, хил хамгаалах чиглэлээр хамтран ажиллах боломжийг тандах, хоёр орны цагдаагийн байгууллагууд шууд хамтран ажиллах эрх зүйн үндсийг тодорхойлох, цагдаагийн байгууллагын боловсон хүчнийг бэлтгэх, чадавхжуулах, биеэ үнэлэхтэй тэмцэх тухай Шведийн хуулийн загварыг судалж үзэх зэрэг асуудлыг хөндсөн. Монгол Улсын иргэд хар тамхи, хүн худалдаалах зэрэг хил дамнасан гэмт хэрэгт өртөх тохиолдолд нэмэгдэж байгааг харгалзан монгол иргэд олноор оршин суудаг, дамжин өнгөрдөг улстай хамтран энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогч болсон иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Энэ хүрээнд хууль сахиулах, хил, гаалийн байгууллагын хамтын ажиллагааг дэмжих, мэдээлэл солилцоог шуурхай болгох мөн гэмт хэргээс сэргийлэх, сэрэмжлүүлэх чиглэлээр олон нийтийн сүлжээ болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сэрэмжлүүлэг, анхааруулга гаргахаас гадна зарим улсад хууль зүйн зөвлөгөө өгөх төвийг ажиллуулж эхлээд байна.</p>

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.124. Шүүх эрх мэдлийн тогтолцоог Монгол Улсын олон улсын үүрэг амлалтад нийцүүлэн шинэчлэх ажлаа үргэлжлүүлэх /ОХУ/</p>	<p>Шүүх эрх мэдлийн тогтолцооны шинэчлэлийн хүрээнд шүүхийн багц хуулиудыг батлуулан хэрэгжүүлж байна.</p>
	<p>108.125. Бүх аймагт байгуулагдсан Хууль зүйн туслалцааны төвүүдийг шаардлагатай санхүүжилт, шалгуур хангасан боловсон хүчнээр хангах замаар эрх зүйн туслалцаа авах боломжийг нэмэгдүүлэх /Литва/</p>	<p>Хууль зүйн туслалцааны төв нь Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1–т заасны дагуу зөвхөн улсын төсвөөс санхүүждэг төрийн байгууллага бөгөөд тус төвийн төсвийг 2016 онд 846 сая, 2017 онд 891 сая, 2018 онд 907 сая төгрөгөөр тус тус баталж, сүүлийн жилүүдэд төсвийг ямагт нэмэгдүүлж ирсэн байна. Түүнчлэн дотоод зохион байгуулалтын арга хэмжээ авч өмгөөлөгчийн орон тоог 3–аар нэмж ажиллаж байгаа бөгөөд Улсын өмгөөлөгчид бүгд Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуульд заасан шалгуурыг хангасан өмгөөлөгчид болно.</p> <p>Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2–т заасны дагуу тус төвийн ажлын албаны албанд төрийн албан хаагчийн мэргэшлийн шалгалтанд тэнцсэн төрийн жинхэнэ албан хаагчид ажилладаг, харин төвийн салбарт шүүхэд төлөөлөх эрхтэй, тухайн нутаг дэвсгэрт ажиллах боломжтой, бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй эрх зүйч мэргэжилтэй, төлбөрийн чадваргүй иргэдэд үйлчлэх чин эрмэлзлэлтэй хуульчийг сонгон шалгаруулж ажиллуулдаг.</p> <p>Тус төв нь хууль зүйн туслалцааг үзүүлэх мэргэшсэн баг бүрдүүлж чадсан бөгөөд төвийн салбар нийслэлийн 8 дүүрэг, 21 аймаг болон 2 суманд байрлан ажиллаж байгаа нь тухайн нутаг дэвсгэрийн иргэдэд хууль зүйн туслалцааны үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, тэдэнд шуурхай үйлчлэх зорилгодоо нийцсэн бөгөөд иргэдийн хууль зүйн туслалцаа авах, шударга шүүхээр шүүлгэх, хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх эрхийг ханган ажиллаж байна.</p>

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
108.125. Бүх аймагт байгуулагдсан Хууль зүйн туслалцааны төвүүдийг шаардлагатай санхүүжилт, шалгуур хангасан боловсон хүчнээр хангах замаар эрх зүйн туслалцаа авах боломжийг нэмэгдүүлэх /Литва/	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/64 тоот тушаалаар Хууль зүйн туслалцааны тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулах Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Хууль зүйн туслалцааны тухай хуулийн төсөлд иргэн болон захиргааны хэргийн төлбөрийн чадваргүй, эмзэг бүлгийн холбогдогчдод хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх асуудлыг тусгахаар төлөвлөж байна.	
108.126. Ял шийтгэлгүй үлдэх явдалтай тэмцэх, эрүүдэн шүүгдсэний улмаас хохирсон хохирогчид хангалттай хэмжээний нөхөн олговор болон нөхөн сэргээх үйлчилгээ авах нөхцлийг хангах үүднээс эрүүдэн шүүсэн болон зүй бусаар харьцсан байж болзошгүй хэрэгт бие даасан, үр нөлөө бүхий мөрдөн шалгах ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэх /Герман/	108.72, 108.73–ыг үзнэ үү.	
108.127. Бүх гэмт этгээдэд ял оногдуулах, хохирогчид цаг алдалгүй эрхээ сэргээлгэх, хамгаалалт авах нөхцлийг бүрдүүлэх /Литва/	108.72, 108.73–ыг үзнэ үү.	
108.128. Насанд хүрээгүй хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх цогц тогтолцоог олон улсын стандартад нийцүүлэн бий болгох /Сиерра Леон/	Судалж байна	
108.129. Иргэддээ тогтвортой хөгжил, тэгш байдлыг бүрдүүлэх үүднээс авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх арга хэмжээгээ үргэлжлүүлэн авах /Сингапур/	2016 оны 12 дугаар сарын 9–ний өдөр Авлигатай тэмцэх газартай хамтран “Авлига ба хүний эрх” бага хурлыг амжилттай зохион байгуулж хуралд “Хүний эрхийг хангах эрх зүйн зохицуулалт”, “Хүний эрх ба авлигатай тэмцэх бусад улсын туршлага”, “Авлига, албан тушаалын гэмт явдлаас хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад шүүхийн гүйцэтгэх үүрэг, анхаарах зарим асуудал”, “Хүний эрх ба авлига”, “Шударга ёсыг тогтоох, хүний эрхийг хамгаалахад прокурорын үүрэг оролцоо” зэрэг сэдвээр Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам, Авлигатай тэмцэх газар, “Эмнести интернэшнл” төрийн бус байгууллагын төлөөлөл илтгэл тавьж, олон нийтэд мэдээлэл өгөв /ГХЯ/.	

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	108.130. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тогтолцоон дахь авлигын бүх хэргийг мөрдөн шалгах /Литва/	Авилгатай тэмцэх газар өөрийн бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. УИХ-ын Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” –г батлан хэрэгжүүлж байна.
	108.131. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй холбогдох үндэсний хууль тогтоомжийг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад нийцүүлэх, Харилцаа, холбооны зохицуулах хорооны хараат бус байдлыг хангах /Швейцарь/	Судалж байна.
	108.132. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй холбогдох хууль тогтоомж, захиргааны шийдвэрийг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактаар хүлээсэн Монгол Улсын үүрэгт бүрэн дүүрэн нийцүүлэх, нэр төр гутаахыг эрүүгийн гэмт хэрэгт тооцохгүй байх асуудлыг судлан үзэх /АНУ/	Эрүүгийн хуулиар гүтгэх, доромжлох үйлдлийг гэмт хэрэгт тооцоогүй. Түүнчлэн “санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах” үйлдэл нь “хүнийг гутаан доромжилсон” үйлдэлд хамаарахгүй. Энэ хэсэгт хуулийг буруу тайлбарласан байна. Энэ зүйл нь “гэмт хэрэг үйлдэгчийн эсрэг хохирогчийн хийсэн буруутай үйлдлээс болж гэмт хэрэг үйлдэгч нь хохирогчид хүнд гэмтэл учруулсан” тохиолдлын тухай ойлголт болохыг залруулах нь зүйтэй. Түүнчлэн Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан нь эрүүгийн гэмт хэрэгт хамаарахгүй.
	108.133. Интернет орчинг оролцуулан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулах /Франц/	Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн хүрээнд Харилцаа холбооны зохицуулах хороо нь аливаа цахим контентийн агуулга, веб сайтыг хууль зөрчсөн эсэхийг тогтоох, шууд хандалтыг хязгаарлах чиг үүргийг хэрэгжүүлдэггүй бөгөөд харин холбогдох эрх бүхий байгууллага, улсын байцаагчийн шийдвэр дүгнэлтийн дагуу технологийн зохицуулалт хийх арга хэмжээг авч ажилладаг. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3.3.2, 3.3.4.3, 3.3.4.4, 3.6.1.2–р заалт, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 25.1, 25.2–ийн дагуу интернет орчинд



ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	108.133. Интернет орчинг оролцуулан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулах /Франц/	зохиогчийн эрхийг хамгаалах, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8.1, 8.2–ийн дагуу цахим орчны хүүхэд хамгаалал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.5, 11.6–ийн дагуу цахим сүлжээгээр хүчирхийлэл, аллага хядлага, садар самууныг сурталчлах, Сонгуулийн тухай хуулийн 70.1.6, 70.18, 83–р зүйлийн дагуу бүх нийтийн сонгуулийн үеэр цахим орчин, веб сайттай холбоотой харилцааг тус тус зохицуулсан байдаг. Дээр дурдсан хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 1–р тогтоолын 2 дахь заалтын дагуу мэдээ мэдээллийн веб сайтуудад тавигдах нөхцөл шаардлагыг “Тоон контентийн зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”–д тодорхойлсон ба уг нөхцөл шаардлагын дагуу зөвхөн Оюуны өмчийн улсын байцаагчийн дүгнэлт, Цагдаагийн байгууллага болон Шүүхийн шийдвэрийн дагуу зөрчилтэй веб сайтын Монгол Улсаас хандах хандалтыг хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлдэг. Харин Монгол Улсын бүх нийтийн сонгуулийн үеэр Сонгуулийн ерөнхий хороо болон Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын дүгнэлт шийдвэрийн дагуу зөрчилтэй веб сайтын Монгол Улсаас хандах хандалтыг хязгаарлах арга хэмжээ авч ажиллах үүргийг хуулийн дагуу тус хороо нь хүлээдэг болно. Гэвч хууль бус цахим контентийг устгах, блоклох хүртэлх зохицуулалтыг авч хэрэгжүүлэх хууль эрх зүйн тодорхойгүй байдал, оновчтой зохицуулалтын тогтолцоо байхгүйгээс шалтгаалан цахим орчны контентийн зохицуулалт хангалттай хийгдэж чадахгүй байна. Олон улсад ялангуяа хөгжингүй орнуудад олон нийтийн эрх ашгийн эсрэг, хүүхдэд сөрөг нөлөөтэй, үндэсний аюулгүй байдлын эсрэг агуулгатай хууль бус цахим контентийг хүний үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг хөндөлгүйгээр зохицуулдаг хууль эрх зүйн тогтолцоо бий болсон байна. Иймээс Монгол Улсын хуулийн хэрэгжилтийг цахим орчин, нийгмийн сүлжээнд хангуулах, хүн хуулийн этгээдийг цахим орчинд хамгаалах, ялангуяа цахим орчинд өсвөр үе хүүхдийн эрх, сөрөг нөлөөтэй цахим контентээс хамгаалах оновчтой зохицуулалтын тогтолцоог яаралтай бий болгох шаардлагатай юм.

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	108.134. Интернетийн зохицуулалтын бүх хүрээнд хүний халдашгүй байх эрх болон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг оролцуулан хүний эрхэд бүрэн хүндэтгэлтэй хандах, тэдгээр эрхийг аливаа байдлаар хязгаарлахдаа “хуульд нийцсэн байх”, “зайлшгүй байх” болон “proportionality” байх зарчмыг баримтлах /Герман/	Харилцаа холбооны зохицуулах хорооноос нийтээр дагаж мөрдөх дүрэм журам хянуулж бүртгүүлэхээр ирүүлсэн нийт 9 хэм хэмжээний актаас 2 журам, 2 техникийн нөхцөл шаардлага нийт 4 хэм хэмжээний актыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, 5 хэм хэмжээний актад дүгнэлт хүргүүлэн буцаасан байна. Мөн Сонгуулийн ерөнхий хороо, Харилцаа холбооны зохицуулах хорооны хамтран баталсан 1 журмыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн байна.
	108.135. Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд болон иргэний нийгмийн зүтгэлтнүүд шийтгүүлнэ гэх аливаа айдасгүйгээр өөрсдийн үйл ажиллагаагаа чөлөөтэй эрхлэх бололцоог олон улсын стандартын дагуу хангах /Эстони/	Судалж байна.
	108.136. Нэр төр гутаах үйлдлийг эрүүгийн гэмт хэрэгт тооцохгүй байх, төрийн болон орон нутгийн эрх бүхий байгууллагын үйл ажиллагааг сурвалжилсан, эсхүл шүүмжилсний улмаас мөрдөн хавчигдах, эсхүл дарамт шахалтанд орохгүй байхаас хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх /Чех/	Эрүүгийн хуулиар гүтгэх, доромжлох үйлдлийг гэмт хэрэгт тооцоогүй. Түүнчлэн “санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах” үйлдэл нь “хүнийг гутаан доромжилсон” үйлдэлд хамаарахгүй. Түүнчлэн Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан нь эрүүгийн гэмт хэрэгт хамаарахгүй.
	108.137. Нэр төр гутаах үйлдлийг эрүүгийн гэмт хэргээс хасах, олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэн иргэний журмаар шийдвэрлэх /Ирланд/	108.136–г үзнэ үү.
	108.138. Эрүүгийн хуулийн гүтгэлэг, доромжлолтой холбоотой зүйл заалтыг шүүмжлэлийг таслан зогсоох зорилгоор ашиглахгүй байх, сэтгүүлчдийн мэдээллийн эх сурвалж болон “шүгэлдэгч”-ийг хамгаалах /Австри/	108.136–г үзнэ үү.

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
108.139.	Эмэгтэйчүүдийн оролцоог улс төрийн шийдвэр гаргах түвшинд бэхжүүлэх зорилго бүхий үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх /Серби/	<p>Монгол Улсын Засгийн газар 2016–2020 оны үйл ажиллагааны хөтөлбөртөө “Жендэрийн тэгш байдлыг хангаж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ” хэмээн зорилт дэвшүүлсэн. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэх болон дэлхийн тогтвортой хөгжлийн 5–р зорилтыг хангах хүрээнд “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр 2017–2021”-ийг батлан дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Тогтвортой хөгжил дэх жендэрийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлэх;</li> <li>2. Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, төсөвлөлтийг үндэсний, салбарын, орон нутгийн, байгууллагын түвшинд хөгжүүлэх;</li> <li>3. Эмэгтэй, эрэгтэй хүний гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг, оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн бүх нийтийн жендэрийн боловсрол олгох арга хэмжээний сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг үндэсний хэмжээнд өрнүүлэх;</li> <li>4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бүтцийг үндэсний, салбарын, орон нутгийн, байгууллагын түвшинд боловсронгуй болгож, чадавхийг сайжруулах;</li> <li>5. Жендэрт суурилсан хүчирхийлэл болон ялгаварлан гадуурхалттай тэмцэх түүнээс түүнээс урьдчилан сэргийлэх тусламж үйлчилгээг цогцоор нь хөгжүүлэх;</li> <li>6. Улс төр, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг нэмэгдүүлэх зэрэг болно.</li> </ol> <p>Үндэсний хөтөлбөрийн 6 дахь зорилтын хүрээнд төрийн албаны удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийг нэг дэвшүүлэх талаар Төрийн албаны зөвлөл болон улс төрийн намуудтай хамтран ажиллаж эхлээд байна. Үүний үр дүнд 2016–2020 онд сонгогдон ажиллаж байгаа Парламентын 76 суудлаас 63 суудал бүхий Монгол ардын нам дүрэмдээ бүх шатны сонгуульд нэр дэвшигчдийн дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь 25 байсныг 30 болгон нэмэгдүүлсэн. Энэхүү улс төрийн соёл цаашид бусад улс төрийн хүчинд үлгэр дууриал, сайн нөлөөлөл болно хэмээн харж байна.</p>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.140. Эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах ажиллагаанд оролцуулах, өндөр түвшний албан тушаал эрхлүүлэх чиглэлээрх хүчин чармайлтаа бэхжүүлэх, боловсролын болон хөдөлмөрийн салбарт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулах нөхцөлийг хангах /Норвеги/</p>	<p>Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлд дараахь квотыг хуульчилсан байдаг.Үүнд:</p> <p>А. томилогдох төрийн улс төрийн албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл Засгийн газар, аймаг, нийслэлд 15%-иас, дүүрэгт 20%-иас доошгүй байх:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Засгийн газрын гишүүд /сайд/ – 16. Үүнээс: 14 эр– 87.5%, 2 эм–12.5% байна.</li> <li>2. Дэд сайд –13. Үүнээс: эр 8 буюу 61.5, эм 5 буюу 38.5%</li> <li>3. Аймаг, нийслэлийн засаг дарга – 22. Үүнээс: эр 22 буюу 100%</li> <li>4. Дүүргийн Засаг дарга – 9. Үүнээс: 7 эр буюу 77.7%, 2 эм буюу 22.3%</li> </ol> <p>Б. төрийн захиргааны удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл яамдын ТНБД, Засгийн газрын агентлагийн даргын 15%-иас, бусад төв байгууллагын удирдлагын 20%-иас, яамдын газар, хэлтсийн даргын 30%-иас, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, албадын даргын 40%-иас доошгүй байх:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Яамдын Төрийн нарийн бичгийн дарга –13. Үүнээс: эр 13 буюу 100%</li> <li>2. Засгийн газрын агентлагийн дарга – 27. Үүнээс: эр 27 буюу 100%</li> <li>3. Яамдын газар, хэлтэс, албадын дарга –189. Үүнээс: 130 эр буюу 68.7%, 59 эм буюу 31.3%</li> <li>4. Нийслэлийн засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, албадын дарга –10. Үүнээс: 8 эр буюу 80%, 2 эм буюу 20%</li> <li>5. Аймгуудын засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, албадын дарга 108. Үүнээс 71 эр буюу 65.7%, 37 эм буюу 34.3%</li> </ol> <p>В. зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэргийн, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, авилгалтай тэмцэх болон онцгой байдлын байгууллагаас бусад байгууллагын төрийн тусгай албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл 40%-иас доошгүй байх:</p>

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.140. Эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах ажиллагаанд оролцуулах, өндөр түвшний албан тушаал эрхлүүлэх чиглэлээрх хүчин чармайлтаа бэхжүүлэх, боловсролын болон хөдөлмөрийн салбарт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулах нөхцөлийг хангах /Норвеги/</p>	<p>Үүнд: төрийн албаны тусгай албан тушаалын ангилалд эрэгтэй хүйс давамгайлсан хэвээр байна. Хэдийн ийм боловч эмэгтэй ажилтны тоо нэмэгдэх хандлага байна.</p> <p>Г. төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд 40:60 гэсэн харьцааг хангах:</p> <p>Үүнд: Төрийн албаны төрийн үйлчилгээний ангилалд удирдах болон гүйцэтгэх албан тушаалд эмэгтэйчүүд илт /70–80 хувь/ давамгайлж байна. Цаашид тус салбарт ажиллах эрэгтэй ажиллагчдын тоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллаж байна.</p>
	<p>108.141. Шийдвэр гаргах түвшний албан тушаал эрхлэх эмэгтэйчүүдийн төлөөллийг өсгөн нэмэгдүүлэх чиглэлээрх хүчин чармайлтаа эрчимжүүлэх /Руанда/</p>	<p>Монгол Улсын 2016–2020 онд байгуулагдсан Парламентад 13 эмэгтэй гишүүн сонгогдон ажиллаж байгаа нь өмнөх жилүүдээс хамгийн их суудал авсан буюу 17 хувийг эзэлж байна. Мөн яамд, засгийн газрын агентлаг, нийслэл, аймаг, дүүргийн газар, хэлтсийн дарга нарын 40 хүртэл хувьд нь эмэгтэйчүүд томилогдон ажиллаж байна. Цаашид төрийн албаны улс төрийн албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэхэд анхаарна.</p>
	<p>108.142. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог баталгаажуулахад чиглэсэн квотын шаардлага зэрэг түр тусгай хэмжээг авах /Коста Рика/</p>	<p>108.140–ыг үзнэ үү.</p> <p>2015 оны Сонгуулийн тухай хуульд нам, эвслийн нэр 20–иос доошгүй хувь нь эмэгтэйчүүд байх заалтыг 30 хувь байхаар нэмэгдүүлсэн нь шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хангахад дэвшил болсон заалт болсон.</p> <p>Түүнчлэн улс төрийн намууд дүрмэндээ намын шийдвэр гаргах удирдах байгууллагад эмэгтэйчүүдийн төлөөллийг 20–40 хувь байхаар тусган ажиллаж байна. Тухайлбал: Ардчилсан намын Үндэсний зөвлөлдөх хорооны 154 гишүүний 51 нь, Монгол Ардын намын Бага хурлын гишүүд болон Удирдах зөвлөлийн гишүүдийн 20 хувь нь эмэгтэй, Иргэний Зориг ногоон намын Удирдах зөвлөлийн гишүүдийн 50 хувь нь эмэгтэй байхаар тус тус намын дүрмэндээ тусгасан.</p>

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц																																																
	<p>108.142. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог баталгаажуулахад чиглэсэн квотын шаардлага зэрэг түр тусгай хэмжээг авах /Коста Рика/</p>	<p>2016 оны УИХ-ын сонгуулиар нийт 13 эмэгтэй гишүүн сонгогдсон нь нийт гишүүдийн 17.1 хувь болж байна. Энэ нь 2012 оны сонгуулиас 2,6 хувиар өссөн байна.</p> <table border="1" data-bbox="626 411 1153 734"> <thead> <tr> <th>Үзүүлэлт</th> <th>2000</th> <th>2004</th> <th>2008</th> <th>2012</th> <th>2016</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Бүгд</td> <td>76</td> <td>76</td> <td>76</td> <td>76</td> <td>76</td> </tr> <tr> <td>Эрэгтэй</td> <td>67</td> <td>71</td> <td>73</td> <td>65</td> <td>63</td> </tr> <tr> <td>Эмэгтэй</td> <td>9</td> <td>5</td> <td>3</td> <td>11</td> <td>13</td> </tr> <tr> <td colspan="6">хувиар</td> </tr> <tr> <td>Бүгд</td> <td>100.0</td> <td>100.0</td> <td>100.0</td> <td>100.0</td> <td>100.0</td> </tr> <tr> <td>Эрэгтэй</td> <td>88.2</td> <td>93.4</td> <td>96.1</td> <td>85.5</td> <td>82.9</td> </tr> <tr> <td>Эмэгтэй</td> <td>11.8</td> <td>6.6</td> <td>3.9</td> <td>14.5</td> <td>17.1</td> </tr> </tbody> </table> <p>Дээрх үр дүнд хүрэхэд иргэний нийгмийн байгууллага, ялангуяа эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын 20 гаруй жилийн тууштай үйл ажиллагаа чухал нөлөө үзүүлсэн. Мөн Жендэрийн эрх тэгш байдлын хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангахын тулд 2005 оноос Жендэрийн үндэсний хороог байгуулан жендэрийн тэгш эрх, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах чиглэлээр тууштай арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаагийн үр дүн гэж үзэж болно.</p>	Үзүүлэлт	2000	2004	2008	2012	2016	Бүгд	76	76	76	76	76	Эрэгтэй	67	71	73	65	63	Эмэгтэй	9	5	3	11	13	хувиар						Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	Эрэгтэй	88.2	93.4	96.1	85.5	82.9	Эмэгтэй	11.8	6.6	3.9	14.5	17.1
Үзүүлэлт	2000	2004	2008	2012	2016																																													
Бүгд	76	76	76	76	76																																													
Эрэгтэй	67	71	73	65	63																																													
Эмэгтэй	9	5	3	11	13																																													
хувиар																																																		
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0																																													
Эрэгтэй	88.2	93.4	96.1	85.5	82.9																																													
Эмэгтэй	11.8	6.6	3.9	14.5	17.1																																													
	<p>108.143. Нийт хүн ам, ялангуяа нийгмийн эмзэг бүлгийн амьдралын чанарыг сайжруулах амжилттай нийгмийн хөтөлбөрүүдээ цаашид улам бэхжүүлэх /Венесуэл/</p>	<p>108.24–г үзнэ үү.</p>																																																

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

<b>№</b>	<b>Зөвлөмж</b>	<b>Хэрэгжилтийн явц</b>
	<p>108.144. Хотын төвүүдэд нийгмийн хамгийн эмзэг бүлгийн хүмүүс, түүний дотор орон нутгаас шилжин ирсэн хүмүүс нийтийн суурь үйлчилгээ авах боломжтой байх нөхцлийг хангах замаар хотын төвүүдэд тогтвортой хөгжлийг бий болгоход чиглэсэн шаардлагатай арга хэмжээнүүдийг авах /Испани/</p>	<p>– Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын нэг гол асуудал нь “Хүн амын шилжилт хөдөлгөөнийг зохистой түвшинд байлгах” гэж туссан ба гадаад, дотоод шилжилт хөдөлгөөний хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан. Дотоод шилжилт хөдөлгөөний хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр заасан байна:</p> <ul style="list-style-type: none"> <li>• иргэдийн шилжилт хөдөлгөөний бүртгэл, мэдээллийг хүн ам, өрхийн мэдээллийн нэгдсэн сантай уялдуулах, гадаад шилжилт хөдөлгөөний бүртгэл, мэдээллийг сайжруулах;</li> <li>• хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоог бүрдүүлж, хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хот, суурин газар, орон нутгийн тогтвортой хөгжлийг газар зохион байгуулалт, хот байгуулалт, дэд бүтэц, аж үйлдвэр зэрэг бусад салбарын бодлоготой уялдуулах;</li> <li>• хот байгуулалтын ногоон хөгжлийн стандарт, олон улсын стандартад нийцсэн хот, суурин газрыг хөгжүүлж, иргэдийн эрүүл аюулгүй, тохилог амьдрах нөхцөлийг бүрдүүлэх;</li> <li>• малчин өрх, хот айл, жижиг, дунд тариалан эрхлэгчдийн аж ахуй эрхлэлтийг дэмжин орчин үеийн техник, технологи, эрчим хүчээр хангаж, үйлдвэрлэл тогтвортой эрхлэх санхүү, эдийн засаг, эрх зүйн нөхцөлийг бүрдүүлэх;</li> <li>• нийгмийн суурь үйлчилгээний чанар, хүртээмжийг хот, хөдөөд жигд болгох;</li> <li>• байгаль, уур амьсгалын өөрчлөлт, гамшиг, зах зээлийн эрсдэлээс шалтгаалсан шилжилт хөдөлгөөнийг бууруулах, хүн амыг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даван туулах, зохицон амьдрах мэдлэг, чадвартай болгох;</li> <li>• нийслэл, хот, суурин газраас орон нутаг руу чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөнийг урамшуулах;</li> </ul>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.144. Хотын төвүүдэд нийгмийн хамгийн эмзэг бүлгийн хүмүүс, түүний дотор орон нутгаас шилжин ирсэн хүмүүс нийтийн суурь үйлчилгээ авах боломжтой байх нөхцлийг хангах замаар хотын төвүүдэд тогтвортой хөгжлийг бий болгоход чиглэсэн шаардлагатай арга хэмжээнүүдийг авах /Испани/</p>	<p>Эдгээр зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хүн амын шилжих хөдөлгөөний статистик мэдээллийг Үндэсний статистикийн хорооноос гаргаж, 1212.mn сайтад байршуулдаг боллоо. Энд шилжин ирсэн, явсан хүн, аймаг, нийслэл, бүсээр 1983–2016 оны байдлаар гаргасан ба эдгээр мэдээллийг хэн ч, хаанаас ч авч ашилах боломжтой юм.</li> <li>• Барилга, хот байгуулалтын яамнаас “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулахаар ажиллаж байгаа бөгөөд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус яамны төлөөлөл оролцон ажиллаж байна.</li> <li>• Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа ба тус хөтөлбөр нь хөдөөгийн залуу болон цөөн малтай өрхийг дэмжих зорилготой.</li> <li>• Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд нийгмийн суурь үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, байгалийн гамшиг, аюул ослоос өөрийгөө болн бусдыг хамгаалах, урьдчилан сэргийлэх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байгаа зэрэг болно.</li> </ul> <p>НҮБ–ын Хүн амын сангийн санхүүжилт, ХНХЯ–ны захиалгаар Хүний хөгжил, сургалт судалгааны төв ТББ “Гадаад шилжих хөдөлгөөний тоон болон чанарын судалгаа”–г хийсэн судалгааны үр дүнг гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах талаарх хууль тогтоомж, гэрээ хэлэлцээрийг боловсронгуй болгох ажилд ашиглаж байна.</p>



**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.145. Эрүүл мэндийн суурь үйлчилгээг үндэсний болон бүсийн хэмжээнд үзүүлэх тогтолцоог бэхжүүлэх, үйлчилгээний хамрах хүрээ болон хүртээмжийг өсгөн нэмэгдүүлэх, эрүүл мэндийн тогтолцоонд буй хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэхэд анхаарал хандуулах /Бутан/</p>	<p>2018 онд Бельгийн Вант улсын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд Ховд аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн тоног төхөөрөмж шинэчлэх ажил хийгдэж байна.</p> <p>Мэргэжлийн хяналтын байгууллагаас их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн эмнэлгүүдэд төлөвлөгөөт хяналт хийх, Хяналт шалгалтанд хамрагдсан эмнэлгүүдэд Сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн хангалт, ажлын ачааллын байдалд тандалт судалгаа, Эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэгч эмчийн хүрэлцээ, мэргэжил, туршлагын байдалд 19 аймгийн Сумын эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвийг хамруулсан судалгааг тус тус хийгээд байна.</p>
	<p>108.146. Эмэгтэйчүүд, хүүхдүүдийн эрхийг хөхиүлэн дэмжих хүчин чармайлтаа үргэлжлүүлэх, одоог хүртэл өндөр түвшинд байгаа эхийн эндэгдлийг бууруулах чиглэлээр ажиллах /Непал/</p>	<p><b>2018 оны эхний 5 сарын байдлаар: Эхийн эндэгдэл ба ноцтой хүндрэлийн талаар:</b></p> <p>2018 оны эхний 5 сарын байдлаар эхийн эндэгдэл, эхийн эндэгдлийн харьцаа өмнөх оны мөн үеэс 4 тохиолдлоор нэмэгдсэн боловч эхийн ноцтой хүндрэл ба харьцаа буурсан байна.</p> <p>2018 оны эхний 5 сард эндсэн 11 эхийн 6 нь Улаанбаатар хотын эмнэлэгт, 4 нь аймаг орон нутгийн эмнэлэгт эндсэн.</p> <p>Эндсэн эхчүүд жирэмсний хяналтанд бүгд хамрагдсан боловч 3 эх – хожуу үедээ хяналтанд орсон байна.</p> <p>2018 оны эхний 5 сард эндсэн (n=11) эхийн 5–эх барихын шалтгаанаар, 6–эх барихын бус шалтгаанаар энджээ.</p> <p>Эхийн ноцтой хүндрэл, эрхтэн тогтолцооны үйл ажиллагааны алдагдлын зонхилох шалтгаан нь умайн үйл ажиллагааны алдагдал байна. Цус бүлэгнэлтийн</p>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.146. Эмэгтэйчүүд, хүүхдүүдийн эрхийг хөхиүлэн дэмжих хүчин чармайлтаа үргэлжлүүлэх, одоог хүртэл өндөр түвшинд байгаа эхийн эндэгдлийг бууруулах чиглэлээр ажиллах /Непал/</p>	<p>алдагдал болон зүрх судасны үйл ажиллагааны алдагдал цөөнгүй тохиолдож байгааг анхаарах нь зүйтэй.</p> <p>2018 оны эхний 5 сарын байдлаар эхийн ноцтой хүндрэлийн 99 тохиолдлын багагүй хувийг өсвөр насныхан эзэлж байна. Мөн 35 ба түүнээс дээш насны, эрсдэлт бүлгийн эмэгтэйчүүд ноцтой хүндрэлээр хүндэрсэн байна. Эдгээр нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөөний дагуу нарийвчилсан төлөвлөгөө гарган донор байгууллагуудын дэмжлэг авч бодитой ажил зохион байгуулах хэрэгтэй байна. 2017 оны байдлаар нийт төрөлтөд охидын төрөлт нийт төрөлтөд ..... хувь эзэлж байгаа нь өсвөр насныханд зориулсан эрүүл мэндийн үйлчилгээ хомс, мөн тэдний жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийн хэрэгцээ хангагдаагүй байгааг илтгэсэн ихээхэн ноцтой чиг хандлага юм. /Баримтын хуудас 2018/ Иймд ЭМС-ын 2017 оны 10 дугаар сарын 17-ны ЭМС-ын А/399 тоот тушаалаар “Өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах арга хэмжээний тухай” тушаалыг мөрдлөг болгон хэрэгжүүлэх үйл ажиллагаа явагдаж байна.</p>
	<p>108.147. Эхийн эндэгдлийг бууруулах чиглэлээрх хүчин чармайлтаа үргэлжлүүлэх /БНАСУ/</p>	<p>“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн үндэсний хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2017 оны 78 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлж байна. “Эх яагаад эндэв 2012–2015” судалгааг хийж, дүнг хэвлүүлэн эмч мэргэжилтнүүдэд түгээсэн.</p> <p>НҮБ-ын Хүн амын сангаас хэрэгжүүлж буй “Эх, нярайн тусламжид зайн оношилгоо төсөл”-ийн санхүүжилтээр эх, нярайн тусламжид шаардлагатай 1,2 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгээд байна. Эх баригчийн ур чадварын суурь судалгааг хийж зөвлөмж гарын авлагыг хэвлүүлэн түгээж, зөвлөмжийн дагуу эх баригчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн Эрүүл мэндийн сайдын А/216 дугаар тушаалаар батлав.</p> <p>Шинэ зеландын Оакландын их сургуульд Эх ургийн анагаах ухааны чиглэлээр ЭХЭМҮТ-ийн 8 эх барих, эмэгтэйчүүдийн эмч 3 жил эчнээгээр суралцаж Эх ургийн</p>

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
		<p>анагаах ухааны эмч мэргэжлийн дипломтай төгслөө. 2016 оны эх барихын шалгаант эхийн эндэгдлийн зонхилох шалтгаануудын нэг болох эх барихын үжил, халдвараар ЭХЭМҮТ, Улаанбаатар хотын 3 амаржих газар, Багануур, Налайх дүүргүүдэд үнэлгээ хийж байна. Эх барихын бус шалтгаан өвчлөл эндэгдлийг бууруулах зорилгоор 21 аймаг, Улаанбаатар хотын дүүргийн дотрын эмч нарт эх барихын эрхтэн тогтолцооны хавсарсан эмгэг сэдвээр сургалт явуулав.</p>
108.148.	<p>Эхийн эндэгдлийн хувь хэмжээг, ялангуяа орон нутагт улам бууруулахад чиглэсэн практик алхмаа үргэлжлүүлэх /Сингапур/</p>	<p>Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд улсын хэмжээний зөвлөх төв Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмч, судлаачдаас бүрдсэн баг 2018 оны 05–06 сард эх, хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийн түвшин өндөртэй 11 аймагт хариу арга хэмжээ, дэмжлэгт хяналт хийж, илэрсэн алдаа зөрчлийг газар дээр нь засуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. ЭХЭМҮТ–ийн Ерөнхий захирлын 2018 оны 06 дугаар сарын 491 дугаар албан тоотоор Эх, хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийн түвшин өндөртэй 11 аймагт дэмжлэгт хяналт, хариу арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажлын нэгдсэн дүгнэлт, зөвлөмжийг Нийслэлийн эрүүл мэндийн газар, 21 аймаг, 9 дүүрэг, амаржих газар, хувийн хэвшлийн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төв бүхий 50 гаруй байгууллагад хүргүүлээд байна.</p>
108.149.	<p>Орон нутаг болон хот суурин газар дахь хүүхдийн эндэгдлийн хувь хэмжээний зөрүүг бууруулах чиглэлээр хүчин чармайлт гарган ажиллах /Гондурас/</p>	<p>Хүүхдийн эндэгдэл өндөртэй аймгуудад туршлагатай эмчийг солилцуулан ажиллуулж, ажлын байрны сургалт зохион байгуулсан. Тухайлбал Дорнод, Өвөрхангай, Хөвсгөл, Дундговь, Баян-өлгий аймгуудын 6 эмч хүүхдийн нүд судлал (1 сар), эмнэлгийн тоног төхөөрөмж (14 хоног), хүүхдийн эрүү, нүүрний мэс засал, хүүхдийн мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний (2 сар) чиглэлээр 2017 онд Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд /ЭХЭМҮТ/ ажлын байрны сургалтад хамрууллаа. ЭХЭМҮТ–ийн хүүхдийн эмнэлгийн эмч нар 2017 онд Өвөрхангай,</p>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.149. Орон нутаг болон хот суурин газар дахь хүүхдийн эндэгдлийн хувь хэмжээний зөрүүг бууруулах чиглэлээр хүчин чармайлт гарган ажиллах /Гондурас/</p>	<p>Хөвсгөл, Говьсүмбэр, Архангай, Баян-Өлгий, Орхон, Булган, Сүхбаатар, Сэлэнгэ, Дорнод, Дархан-Уул, Дундговь аймагт Хүүхдийн өвчний цогц менежмент, хүүхэд, нярайд тохиолдох эмгэгүүд, нярайн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээ, хүүхдэд зонхилон тохиолдох зүрхний эмгэгүүдийн талаар ажлын байр дээрх сургалтуудыг зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллалаа.</p> <p>“Хүүхэд яагаад эндэв? 2016” цогц судалгааг олон улсын арга аргачлал, жишгийн дагуу анх удаа хийж, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ чиглэлүүдийг зөвлөмж болгосон.</p> <p>“Хүүхдийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний тулгамдсан асуудал” хэлэлцүүлгийг аймаг, нийслэлийн хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд 2017 оны 11 сарын 24–25–ны өдрүүдэд зохион байгуулж, эх, хүүхдэд ээлтэй тусламж, үйлчилгээг зохион байгуулах, анхаарах асуудлуудын талаар мэдээлэл өгөв.</p> <p>“Эх, хүүхдийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал” Үндэсний зөвлөгөөнийг 2017 оны 11 дүгээр сарын 22–23–ны өдрүүдэд зохион байгуулав. Уг зөвлөгөөнд аймгийн засаг дарга нар, аймаг нийслэлийн ЭМГ–ын дарга нар, эх барих, эмэгтэйчүүдийн эмч, хүүхдийн мэргэжилтнүүд нийт 150 хүн оролцов. Зөвлөгөөнөөр эх, хүүхдийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг тодорхойлж, түүнийг шийдвэрлэх арга замын талаар санал солилцож, зөвлөмж гаргав. Аймгуудын засаг дарга нар оролцож, эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр хийсэн ажлын танилцуулга хийж, саналаа илэрхийлсэн нь салбар дундын хамтын ажиллагаанд анхаарал хандуулснаараа онцлог байв.</p> <p>Дорноговь аймгийн Засаг даргын ивээл дор зохион байгуулагдсан “Хүүхдийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага” Говийн бүсийн зөвлөгөөнд оролцож, Эрүүл мэндийн яамнаас</p>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
		<p>хэрэгжүүлж буй бодлого шийдвэрүүдийн талаар болон говийн аймгуудын хүүхдэд үзүүлж буй тусламж үйлчилгээний талаар илтгэл хэлэлцүүлэн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал бодлоо солилцлоо. Уг зөвлөгөөнөөр бага насны хүүхдийн түүн дотроо нярайн эрт үеийн эндэгдлийг бууруулах, нярайн сурьфактант эмчилгээг нэвтрүүлэх зэрэг олон чухал асуудлыг хэлэлцсэн нь чухал ач холбогдолтой байв.</p>
	<p>108.150. “Нэг Монгол” нээлттэй боловсролын үндэсний хөтөлбөрөө сайжруулан ажиллах /Латви/</p>	<p>Засгийн газрын 2014 оны 105 дугаар тогтоолоор Нээлттэй боловсролын “Нэг Монгол” үндэсний хөтөлбөрийг баталсан. Хөтөлбөрийн хүрээнд дараах ажлыг хийгээд байна.</p> <p><b>Зорилт 1: 3.1. “Нээлттэй академи” төсөл</b></p> <p>Хүүхдийн итгэл, найдвар, сурах тэмүүллийг нь дэмжиж, сургалтыг суралцагч өөрийн үйл явцад суралцдаг арга зүйд суурилсан “ерөнхий боловсролын сургуулийн сурагч, багш нарт зориулсан үнэ төлбөргүй, нээлттэй онлайн боловсролын үйлчилгээ”-г боловсролын тогтолцоонд нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлнэ. Төслийн хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Ерөнхий боловсролын сургалтын математик, дэлхийн түүх, мэдээллийн технологи, биологийн 813 видео хичээлийг орчуулан <a href="http://www.mn.khanacademy.org">http://www.mn.khanacademy.org</a> вэб сайтад байршуулж үнэ төлбөргүй ашиглах боломжийг бүрдүүлсэн.</li> <li>- Хан Академийн хичээлүүдийг сургалтандаа ашигладаг багш, сурагчид, дэмжигчид, боловсролын байгууллагын мэргэжилтнүүдийг нэгтгэн мэдээллээ солилцох, хамтын ажиллагааг өрнүүлэх талбар бий болгож Хан Академийн дэмжигчдийн клубын <a href="http://www.k12.mn">http://www.k12.mn</a> сошиал вэб сайтыг нээн ажиллуулж байна. <a href="http://www.econtent.edu.mn">www.econtent.edu.mn</a> вэб хуудсанд байгалийн ухааны сургалтын интерактив хэрэглэгдэхүүнүүд байрлуулсныг багш нар ашиглаж байна.</li> </ul>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	108.150. “Нэг Монгол” нээлттэй боловсролын үндэсний хөтөлбөрөө сайжруулан ажиллах /Латви/	– Цахим сургалтын системийн тоног төхөөрөмжийг боловсролын дата төвд угсарч, суурилуулж, тохиргоо хийж дууссан.

**Зорилт 2: 3.2. “Монгол хэл” төсөл**

Монгол Улс үндэстэн оршихуйн үндэс болсон эх хэл, соёл, сэтгэлгээний үндэсний дархлааг бэхжүүлэх, бүх түвшний боловсрол, сургалтын чанар, иргэдийн харилцааны соёлын түвшинг дээшлүүлэх зорилгоор бүх нийтийн монгол кирилл бичгийн нээлттэй сургалтын орчинг бий болгох “Монгол хэл” төслийг хэрэгжүүлнэ. Төслийн хүрээнд:

- Монгол хэлний 50 мянга орчим үг хэллэгийн дэлгэрэнгүй тайлбар бүхий нээлттэй вики-толь бичгийг бүтээж, тасралтгүй хөгжүүлэх үүднээс салбарын мэргэжилтнүүд, сонирхсон бүх хүмүүс өргөнөөр, нээлттэйгээр оролцох боломжийг бүрдүүллээ. <http://mn.wiktionary.org>
- Монгол кирилл бичгийн дүрмийн алдаа засах системийг хөгжүүлж <http://www.spellcheck.gov.mn/> хаягаар 2013 оноос байршуулан үнэ төлбөргүйгээр ашиглах боломжийг бүрдүүлсэн. Түүнчлэн, нэн түгээмэл, MS Office, Libre Office, Open Office зэрэг системүүдэд суурилуулах хувилбаруудыг үнэ төлбөргүйгээр ашиглах боломжтой болсон.

**Зорилт 3: 3.3. “Нээлттэй их сургууль” төсөл**

Үндэсний эдийн засаг, хөдөлмөрийн зах зээлд өндөр эрэлттэй их, дээд сургуулийн хөтөлбөрүүдийг хөгжингүй орнуудын дэлхийн шилдэг их сургуулиудын түвшинд боловсруулж цахим, видео, виртуал хэлбэрт шилжүүлэн нээлттэй хэлбэрээр суралцах боломжийг бий болгоно. Төслийн хүрээнд:

- МУИС–ийн Номын сан 2017–2018 оны хичээлийн жилд орчин үеийн дизайны шийдэл бүхий ая тухтай орчинг

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.150. “Нэг Монгол” нээлттэй боловсролын үндэсний хөтөлбөрөө сайжруулан ажиллах /Латви/</p>	<p>– бүрдүүлсэн номын сангийн шинэ байранд нүүн орж, МУИС төдийгүй Монголын дээд боловсролын салбарын номын сангийн нүүр царай болохуйц эрдэм шинжилгээ, сургалт–судалгааны түшиц номын сан– мэдээллийн төв нээгдсэн.</p> <p>– Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр МУИС–д түшиглэн гурван тэрбум орчим төгрөгийн өртөг бүхий “Лазерын судалгааны лаборатори”–ийг байгуулсан.</p> <p><b>Зорилт 4: 3.4. “Үнэн түүх” төсөл</b></p> <p>Монголчуудын угсаа, гарвал, үнэн бодит түүхийг үр хүүхэд, залуучууд, нийт иргэд, дэлхий нийтэд мэдүүлж таниулах, үндэсний бахархал, ухамсар, үнэт зүйлсийг хөгжүүлэн бэхжүүлэх “Үнэн түүх” төслийг хэрэгжүүлнэ. Төслийн хүрээнд:</p> <p>– “Эртний буриад дуу, зохиолын дуу, ардын дуу”– ны төрлүүдэд оролцсон үеийн дүрс бичлэг, бүх ард түмний урлаг спортын наадмын бичлэг, сумын түүхт ойн арга хэмжээ, баярын концертын бичлэг, нутгийн ардын дуу, ерөөл, магтаал, үлгэр, тууль зэрэг өвлөн уламжлагч авьяастнуудын дүрсжүүлсэн дуу бичлэгийг CD, хальсанд буулгаж хураан баримтжуулж хадгалан, цахим хэлбэрт оруулан нийтэд сурталчилж байна.</p> <p>– Интернэт орчинд байрлуулах мэдээллийн сан бий болгох ажлын хүрээнд 30–40 минутын дөрвөн цуврал хичээл болох “Хөөрхөн халиун” –37 минут, “Зээргэнэтийн шил” – 33 минут, “Эрдэнэ засгийн унага” – 35 минут, “Эр бор харцага” –31 минут бэлтгэлээ.</p> <p><b>Зорилт 5:3.5. “Үндэсний соёл” төсөл</b></p> <p>Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид болон бүх нийтэд зориулсан дэлхийн болон монголын утга зохиолын шилдэг бүтээл, зан заншил, түүх, соёлын биет болон биет бус үнэт өвийг танилцуулах цахим, видео, виртуал, нээлттэй мэдээллийн санг байгуулна. Төслийн хүрээнд:</p> <p>– Мэргэжлийн урлагийн байгууллагын 40 жилийн ойн хүрээнд “Эрдэнэсийн хотын эгшиглэнт урлаг” нэртэй үе үеийн уран</p>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.150. “Нэг Монгол” нээлттэй боловсролын үндэсний хөтөлбөрөө сайжруулан ажиллах /Латви/</p>	<p>бүтээлчдийн түүх намтар, уран бүтээлийн түүх, мэргэжлийн урлагийн байгууллагын түүхийг агуулсан 322 хуудастай номыг бүтээлээ.</p> <ul style="list-style-type: none"> <li>– Соёлын биет бус өв тээгч МУГЖ Х.Цэрэнчимэдэд хадгалагдаж байсан ховор бүтээлийн нэг “Алтан галуу ноён хүү” туулийг сэргээн, Монголын үндэсний телевизтэй хамтран баримтат кино бүтээн, үндэсний хэмжээнд түгээн сурталчиллаа.</li> <li>– Язгуур урлагийн дугуйланг 15 суманд ажиллуулж нийт 82 хүүхдэд ерөөл магтаал, зүйр цэцэн үг, түргэн хэллэг, дайралцаа, хэлц үг, оньсого таалцах тоглоом зэрэг аман цэц билгийн өв санг сэргээн, түгээн дэлгэрүүлж эзэмшүүлж өвлүүллээ.</li> </ul> <p><b>Зорилт 6:3.6. “Нээлттэй мэдлэг” төсөл</b></p> <p>Нээлттэй мэдлэгийн үндэсний нэгдмэл санг бий болгох, шинжлэх ухаан, үйлдвэрлэл, бизнесийн ноу хауг хөгжүүлэх, мэдлэг, бизнес–инноваци, технологийг бүтээх, хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, шинжлэх ухаан, өндөр технологид суурилсан өрсөлдөх чадамжтай үндэсний эдийн засаг, үйлдвэрлэлийн хөгжлийг эрчимжүүлэхэд чиглэсэн “Нээлттэй мэдлэг” төслийг хэрэгжүүлнэ.</p> <p>Төслийн хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>– “Шинжлэх ухаан, технологийн салбарын мэдээлэл, удирдлагын нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх” төслийн хүрээнд <a href="http://www.science.edu.mn">www.science.edu.mn</a> онлайн програм хангамжийг боловсруулсан. Хуваарийн дагуу ШУА–ийн харьяа 7 хүрээлэнгийн мэдээллийг оруулаад байна.</li> </ul>
	<p>108.151. Хүүхэд бүр сурч боловсрох эрхээ эдлэх нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн хүчин чармайлтаа үргэлжлүүлэх /Румын/</p>	



**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

<b>№</b>	<b>Зөвлөмж</b>	<b>Хэрэгжилтийн явц</b>
	<p>108.152. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангаж, хамгаалах, ялангуяа тэдний оролцоог хангах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, сурч боловсрох эрхийн хэрэгжилтийг өргөжүүлэх Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай хуулийн төслийг эцэслэн батлах хүчин чармайлтаа хоёр дахин нэмэгдүүлэх /Индонез/</p>	<p>– Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ–ын Конвенцийн үзэл баримтлалд тулгуурласан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэм зэргийг хүндэтгэсэн, эрхийг дээдэлсэн “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль” болон бусад хуулийг 2016 оны 02 дугаар сарын 05–ны өдрийн УИХ–ын нэгдсэн чуулганаар баталсан. Тус хуулинд хүнийг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхалд өртөхөөс хамгаалах, хориглох, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, нийгмийн харилцаанд бусдын адил тэгш эрхтэй оролцох боломжийг хангахад чиглэгдсэн эрх зүйн зохицуулалтыг тусгаж өгсөн.</p> <p>Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүнд нэн тэргүүн тулгамдаж буй нийтийн тээвэр, зам, орон сууц, тэдний хэрэгцээ шаардлагыг хангахгүй асуудлыг сайжруулах арга хэмжээг хуульчилсан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүн хууль зүйн туслалцаа авах эрх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрх, улс төрийн үйл ажиллагаанд оролцох, хувийн нууцыг хүндэтгэх, бие даан амьдрах эрхтэй байх, биеийн тамир, спортын, соёл, урлагийн үйл ажиллагааны хүртээмж, онцгой байдлын үед авах арга хэмжээний эрх зүйн зохицуулалтыг тус тус тусгасан.</p> <p>– Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нийгмийн бүхий л харилцаанд бүрэн дүүрэн оролцох нөхцөлийг бүрдүүлэх, тэдний дуу хоолойг нь олон нийт, шийдвэр гаргах түвшинд хүргэх хөгжлийн бэрхшээлийн талаар эерэг ойлголт, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”–ийг боловсруулан Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолоор батлуулаад байна.</p>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.152. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангаж, хамгаалах, ялангуяа тэдний оролцоог хангах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, сурч боловсрох эрхийн хэрэгжилтийг өргөжүүлэх Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай хуулийн төслийг эцэслэн батлах хүчин чармайлтаа хоёр дахин нэмэгдүүлэх /Индонез/</p>	<p>– Монгол Улсын Засгийн газрын 321 тогтоолын 2 дахь хэсэгт заасны дагуу “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө” батлах тухай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны 05 дугаар сарын 21–ний өдрийн А/116, А/304, А/197 тоот хамтарсан тушаалаар баталлаа. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг яамд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга, холбогдох агентагуудад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын албан бичгээр хүргүүлж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>– Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлж, “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үнэмлэх олгох журам, үнэмлэхийн загвар”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам”, “Мэргэжлийн ур чадварын олон улсын тэмцээнд амжилттай оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүнд урамшуулал олгох”, “Хөтөч нохойг сургах, ашиглах журам”-ыг тус тус батлан хэрэгжүүлж байна.</p> <p>– Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай болон Хөдөлмөрийн тухай хуулийн хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийг шинэчлэн боловсруулж хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэх эхийг хамруулахаар хүрээг өргөжүүлсэн. Мөн хөтөлбөрийн хүрээнд 9 арга хэмжээ, үйлчилгээг үзүүлдэг болгож арга хэмжээний тоог нэмэгдүүлсэн. Хөтөлбөрт 2017 онд 5782 иргэн хамрагдаж 3,2 тэрбум төгрөг зарцуулж, 1144 байнгын, 171 түр ажлын байр бий болсон ба 2018 онд тус хөтөлбөрт 4,4 тэрбум төгрөг төсөвлөн</p>

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

<b>№</b>	<b>Зөвлөмж</b>	<b>Хэрэгжилтийн явц</b>
	<p>108.152. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангаж, хамгаалах, ялангуяа тэдний оролцоог хангах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, сурч боловсрох эрхийн хэрэгжилтийг өргөжүүлэх Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай хуулийн төслийг эцэслэн батлах хүчин чармайлтаа хоёр дахин нэмэгдүүлэх /Индонез/</p>	<p>хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 2018 оны 05 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр нийт 670 иргэн хамрагдаж 549,305.0 мянган төгрөг зарцуулж 206 ажлын байр бий болсон байна. Үүнийг арга хэмжээ тус бүрээр харуулбал:</p> <ul style="list-style-type: none"> <li>– Хөдөлмөрт бэлтгэх 23 иргэн хамрагдаж 1,380.0 мянган төгрөгийг;</li> <li>– Аж ахуйн эрхлэлтийн сургалтанд 440 иргэн хамрагдаж 11,943.0 мянган төгрөгийг;</li> <li>– Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэгт 16 иргэн хамрагдаж 6,742.0 мянган төгрөгийг;</li> <li>– Ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд 3 иргэн, 3 ажил олгогч хамрагдаж 8,640.0 мянган төгрөгийг;</li> <li>– Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 188 иргэн хамрагдаж 203 иргэн ажлын байраар хангагдаж 520,600.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна. Санхүүгийн дэмжлэгээс 3,314.55 мянган төгрөг эргэн төлөгдсөн байна.</li> <li>– Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/140 дугаар тушаалаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгад Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудлыг судлах чиг үүрэг бүхий дэд ажлын хэсэг байгуулагдаж ажиллаж байна. Энэ хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудад дээрх хуулийн үзэл баримтлалын төслийг танилцуулан, санал авсан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бүлгийн төслийг боловсруулж байна.</li> <li>– “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай” НҮБ–ын конвенци, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, эрх чөлөөг аливаа ялгаваргүйгээр, бүрэн эдлэх нөхцлийг бүрдүүлэхтэй</li> </ul>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.152. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангаж, хамгаалах, ялангуяа тэдний оролцоог хангах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, сурч боловсрох эрхийн хэрэгжилтийг өргөжүүлэх Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай хуулийн төслийг эцэслэн батлах хүчин чармайлтаа хоёр дахин нэмэгдүүлэх /Индонез/</p>	<p>холбогдсон үйл ажиллагааг салбар дундын зохицуулалтаар хангаж, дэмжлэг үзүүлэх Үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд байгуулж, зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газрын 2016 оны 136 дугаар тогтоолоор баталсан. Зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагын төлөөлөл 24 гишүүн багтсан бөгөөд бүх яамдад дэд зөвлөлтэйгээр, 21 аймаг, 9 дүүрэгт салбар зөвлөлтэйгээр ажиллаж байна.</p>
	<p>108.153. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлээрх нааштай хүчин чармайлтаа үргэлжлүүлэх /Аргентин/</p>	<p>108.24, 108.152–оос үзнэ үү.</p>
	<p>108.154. Бүх төрлийн ялгаварлан гадуурхалт, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настай хүмүүсийн эрхийг хамгаалах тодорхой хууль батлах /Турк/</p>	<p>108.19–өөс үзнэ үү. Ахмад настны тухай хуулийг УИХ–аас 2017.01.27 өдөр баталсан Тус хуульд ахмад настны эрх, амьжиргаа, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, хөгжил оролцоог дэмжих, ахманд настанд үзүүлэх хүндэтгэл, насны хишиг олгох арга хэмжээний талаар тусгасан. Ахмад настны эрхийн асуудлыг тусгайлан бүлэн болгон тэдний эрүүл мэндийн байдал нь харшлахгүй бол ахмад настан өөрийн хүсэл сонирхлын дагуу бие даан амьдрах, зохистой хүнс тэжээл, орон байраар хангагдах өөрийн хүсэл, сонирхлын үндсэн дээр эрүүл мэнд, мэдлэг чадвартаа тохирсон хөдөлмөр эрхлэх, орлого олох, гэр бүлийн гишүүдээс туслалцаа, дэмжлэг авах, ялгаварлан гадуурхсан, үл хайхарсан үйлдэл эс үйлдэхгүйгээс ангид байх, нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцох, эвлэлдэн нэгдэх, нэр төрөө хүндлүүлэх залуу үед өөрсдийнхөө мэдлэг, туршлага, ур чадвараа хуваалцах, өвлүүлэн үлдээх, өөрийн чадавхийг хөгжүүлэх бололцоогоор хангагдах зэрэг эрхийг хуулиар баталгаажуулсан. Мөн лавлагаа, мэдээллийн, зөвлөгөө өгөх явуулын, өдөр өнжүүлэх, сайн дурын, гэр</p>

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
		<p>бүлийн хүчирхийллээс хамгаалах зэрэг ахмад настанд үзүүлэх үйлчилгээний төрлийг нэмэгдүүлсэн. Ахмад настны нийгмийн хамгаалалд анхаарч 65 ба түүнээс дээш настанд жилд 2 удаас “насны хишиг” буюу тэтгэвэр дээр нь нэмж өндөр насласных нь төлөө тэтгэмж олгож байна. Хуулийг хэрэгжүүлэхэд жилд дундажаар 20.5 тэрбус төгрөг шаардлагатай байгаа ба хөрөнгийг улсын төсөвт тусгаж байна. Түүнчлэн зарим зардлыг Нийгмийн халамжийн сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын сан зэрэг сангийн үйл ажиллагаатай уялдуулан шийдвэрлэж байна.</p>
108.155.	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл хөгжлийг баталгаажуулсан хамран сургалтанд ач холбогдол өгсөн, боловсролын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх /БНХАУ/</p>	<p>– Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс /ХБХЭМБНХ/ –ын хурлаар орсон хүүхүүдээс 2017 оны байдлаар 239 хүүхдийг СӨБ–д, 314 хүүхдийг ЕБС–д, боловсролын бусад үйлчилгээнд 11 хүүхдийг хамруулсан байна.</p> <p>– ХНХЯ, БСШУСЯ нь JICA–тай хамтран “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах” төслийг 2015–2019 онд хэрэгжүүлж байна. Уг төсөл нь Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн үнэлгээ, хөгжлийн дэмжлэг, боловсролын загвар бий болгох зорилготой. Зорилгодоо хүрэхийн тулд нийт 4 зорилт тавин ажиллаж байна. Төслийн “Зорилт II”–ийг туршилтын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд (Оюуны бэрхшээлтэй хүүхэд) чанартай боловсрол олгох чадвар бэхжинэ гэж тодорхойлсон байгаа. ХБХЭМБНХ–ын комисс энэхүү зорилтын хүрээнд төслийн багийнхантай хамтран дараах үйл ажиллагааг явуулж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Туршилтын 4 тусгай сургууль, 10 Ерөнхий боловсролын сургууль төслийн гол хамтран ажиллагч байгууллагаар сонгогдон ажиллаж байна.</li> <li>• БСШУС–ын сайд, ХНХ–ын сайдын 2016 оны 10 дугаар сарын 21–ний өдрийн</li> </ul>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.155. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл хөгжлийг баталгаажуулсан хамран сургалтанд ач холбогдол өгсөн, боловсролын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх /БНХАУ/</p>	<ul style="list-style-type: none"> <li>• А/86, А/187 дугаар хамтарсан тушаалаар шинэчлэн байгуулагдсан Мэргэжил, арга зүйн баг нь дээр дурдсан туршилтын сургуулиуд дээрх бүтэн 3 жилийн туршилтын явц, тайлан зэргийг үндэслэн Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ гэх) боловсруулах гарын авлага, ГСТ–ний загварыг боловсруулж, БСШУС–ын сайдын 2018 оны 03 дугаар сарын 29–ний өдрийн “Үлгэрчилсэн загвар, аргачлал батлах тухай” А/155 дугаар тушаалаар уг загвар батлагдсан.</li> <li>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохируулгат орчин бүрдүүлэх зорилгоор туршилтын 10 ЕБС тус бүрийн саналыг харгалзан үзэж сургууль тус бүрт 2 сая төгрөгийг олгосон. Сургуулиуд энэ мөнгөөр тус тусын орчныг бүрдүүлэн ажиллаж байна. Одоогийн байдлаар 4 сургууль нь “Хүүхэд хөгжлийн төв”–ийг нээн ажиллуулж байна.</li> <li>• Хөвсгөл аймаг дахь туршилтын 2 сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд хамрагдалтыг дэмжих үйл ажиллагааг туршин хэрэгжүүлж байна. Туршилтын 2 сургууль тус бүрдээ сургуульд хамрагддаггүй, алхаж чаддаггүй, алхах боломжгүй тус бүр 1 хүүхдийг сонгож, 2017 оны 9 дүгээр сараас 7 хоногт 1 удаа гэрээр нь очиж сургалт явуулж байна.</li> <li>• Сонгогдсон сургуулиудад “Багшлах арга зүй”, “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний дадлага”, “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах дадлага”, “Сургууль дахь тохируулгат орчин”, “Хавсарсан бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй”, “Зан төлөв ба мэдрэхүй” зэрэг сэдвүүдээр сургалт–дадлага ажлуудыг удаа дараа явуулсан.             <ul style="list-style-type: none"> <li>– Түүнчлэн төслийн 3 дугаар зорилт буюу “Бичил төслөөр дамжуулан тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд нийцсэн боловсрол, сургалтын төрөл бүрийн арга хэлбэрийг туршин хэрэгжүүлж, үр нөлөөг нь судлах” зорилтын хүрээнд бичил төслийн</li> </ul> </li> </ul>

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

<b>№</b>	<b>Зөвлөмж</b>	<b>Хэрэгжилтийн явц</b>
	<p>108.155. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл хөгжлийг баталгаажуулсан хамран сургалтанд ач холбогдол өгсөн, боловсролын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх /БНХАУ/</p>	<p>уралдаан зарлаж, шалгаруулж байгаа. 2017 онд 3 төслийг шалгаруулж, тус бүрт нь 12 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Тухайлбал, нийслэлийн Баянгол дүүргийн 17 дугаар хороонд байрлах МУБИС–ийн харъяа 249 дүгээр цэцэрлэгийн “Сургуулийн өмнөх насны хүүхдийг боловсролд тэгш хамруулах” төсөл шалгарсан. Уг бичил төсөл нь цэцэрлэгт явдаггүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан бүлгийн сургалтыг долоо хоногт 1 удаа зохион байгуулна. Мөн, цэцэрлэгийн ангид 2 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамруулан сургаж, багш нарын заах аргыг сайжруулах зорилготой юм. Энэхүү төслийг хэрэгжүүлснээр цэцэрлэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйд суралцах юм. Одоогийн байдлаар бичил төсөл хэрэгжүүлсэн байгууллагууд тайлангаа ирүүлж эхлээд байгаа. Ийнхүү бичил төслийг санхүүжүүлэн хэрэгжүүлснээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах орчин нөхцлийг сайжруулахад хувь нэмэр болж байгаа юм.</p>
	<p>108.156. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тухай олон нийтийн ойлголтыг сайжруулах замаар тэдний боловсрол эзэмших тэгш боломжийг хангах /Турк/</p>	<p>ХНХЯ–аас 2016 онд батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Япон улсын Жайка байгууллагатай хамтран 2016–2020 оны хооронд “Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих” төслийг хэрэгжүүлж байна. Энэхүү төсөл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөө ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагуудыг чадавхжуулах, мэдээллийн болон дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх олон нийтийн ойлголт, хандлагыг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдээллийн нэгдсэн сантай болох зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж байна.</p> <p>– Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх олон нийтийн ойлголт хандлага дутмаг байдгаас тэдгээр иргэдийн нийгэмд оролцох оролцоо сул, хууль эрх зүйн</p>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.156. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тухай олон нийтийн ойлголтыг сайжруулах замаар тэдний боловсрол эзэмших тэгш боломжийг хангах /Турк/</p>	<p>мэдлэг ойлголт тааруу, байгууллагууд тэдэнд зориулсан үйлчилгээ явуулж чаддаггүйн улмаас нийгмээс тусгаарлагдаж ялгаварлан гадуурхагдах явдал байсаар байна. Ялангуяа бага насны хүүхдүүд, багш сурган хүмүүжүүлэгчдэд хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт хандлага байхгүйн улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсролын үйлчилгээнд тэгш хамрагдаж чадахгүй, нийгмийн гадна үлдсээр байна. Иймд ХНХЯ нь уг төслийнхөө хүрээнд хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт хандлагыг сайжруулах сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах чиглэлээр 2016 онд ДЕТ “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын сургалт”-ын “Сургагч багш” бэлтгэх сургалтыг зохион байгуулж Монгол Улсад анх удаа үндэсний хэмжээний 32 сургагч багш бэлтгэсэн. Сургагч багш нар нь бүгд хөгжлийн бэрхшээлтэй иргэд байдаг бөгөөд өөрсдийн бэрхшээл дээрээ үндэслэн бусдад ойлголт, хандлага өгдгөөрөө бусад сургалтаас онцлогтой юм. Эдгээр сургагч багш нар 2 жилийн хугацаанд 160 гаруй байгууллагын 5000 гаруй хүмүүсийн хандлага, ойлголтыг нэмэгдүүлээд байна. Энэ хугацаанд ХНХЯ-ы зүгээс төлөвлөгөө гарган төр, захиргааны байгууллага болох НЗДТГ болон 9 дүүргийн ЗДТГ, ХНХЯ-ы харьяа 37 байгууллагад уг сургалтыг зохион байгууллаа. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор “Шинэ Монгол” дунд сургуулийн ахлах ангийн 300 гаран сурагч, Нийслэлийн 65 дугаар сургуулийн 9-11 дүгээр ангийн 250 гаран сурагч, МУБИС-ийн “Нийгмийн ажилтны анги”-ийн 1-4 дүгээр курсын 250 гаруй оюутан, “Тусгай хэрэгцээт боловсрол”-ын ангийн 100 гаруй оюутан, МУИС-ийн хүний эрхийн чиглэлээр суралцаж буй 1 дүгээр курсын 150 гаруй оюутнуудад тус тус зохион байгуулаад ба 2018 оны 08 дугаар сараас ЭМЯ, БСШУСЯ гэх зэрэг төрийн захиргааны төв байгууллагуудаар зохион байгуулахаар төлөвлөөд байна.</p>



ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.157. Боловсролын тогтолцоогоо улам бэхжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсрол эзэмших тэгш боломжийг хангах /Лаос/</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2016–2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар:</p> <ul style="list-style-type: none"><li>– Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх бодлого баримтална.</li><li>– Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үеийн найзуудтайгаа хамт суралцах нөхцөлийг бүрдүүлж шаардлагатай дэд бүтцийг сайжруулна гэж заасан.</li></ul> <p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 01 дүгээр сарын 11–ний өдрийн А/13 тоот тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг байгуулан хийх ажлын төлөвлөгөө боловсруулан дараах ажлуудыг хийгээд байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"><li>1. Ердийн ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах анги, бүлэг нээх харилцааг зохицуулсан журмын төслийн анхны хувилбарыг боловсруулан уг төслийг ерөнхий боловсролын тусгай сургууль болон зарим ЕБС –ийн удирдлага багш нарт танилцуулан зөвлөмж хүргүүлээд байна.</li><li>2. БСШУС–ын сайдын 2018 оны өдрийн “Үлгэрчилсэн загвар, аргачлал батлах тухай” А/155 тушаалаар тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай суралцагчийн хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцсэн “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө”–ний үлгэрчилсэн загварыг баталсан.</li><li>3. Монгол Улсын Их Хурлын 2017 оны “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 46 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд тусгай цэцэрлэг, ерөнхий боловсролын тусгай сургуулийн багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулан 395 багш, удирдах ажилтан, туслах багшийг хамруулан тэдэнд зориулсан гарын авлага бэлтгэн гаргалаа.</li></ol>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.157. Боловсролын тогтолцоогоо улам бэхжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсрол эзэмших тэгш боломжийг хангах /Лаос/</p>	<p>4. Мөн тусгай болон ердийн ерөнхий боловсролын сургуулийн багш нарт зориулан “Хэл заслын үндэс” сургалтыг зохион байгууллаа.</p> <p>5. Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуулийн хичээлийн хонхыг гэрлэн хонхоор сольсон. Мөн Монголын хараагүй иргэдийн үндэсний холбоотой хамтран “Брайль үсгийн стандарт”-ын төслийг боловсруулаад байна.</p> <p>6. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолоор “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг баталсан. Уг хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудлыг бие даасан бүлгээр тусган орууллаа. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/116, А/304, А/197 дугаар хамтарсан тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлан хэрэгжүүлж байна.</p> <p>7. Дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбоотой хамтран “Монгол дохионы хэлний хэлмэрч, орчуулгын үйл ажиллагаа эрхлэх, үйлчилгээ үзүүлэх журам”-ын төслийг боловсруулж хэлэлцүүлээ. Энэхүү журмыг сонсгол, хэл, ярианы бэрхшээлтэй хүний дохио, зангааг хэлмэрчлэх, орчуулах үйл ажиллагаанд мөрдөх бөгөөд уг журам монгол дохионы хэлний хэлмэрч, орчуулгын үйл ажиллагаа эрхлэх, үйлчилгээ үзүүлэхэд баримтлах зарчим, харилцааг тус тус зохицуулж байна.</p> <p>8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд ерөнхий боловсролын тусгай сургуулийн бүх суралцагчийн үдийн хоолны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр заасан.</p>

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

<b>№</b>	<b>Зөвлөмж</b>	<b>Хэрэгжилтийн явц</b>
	<p>108.157. Боловсролын тогтолцоогоо улам бэхжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсрол эзэмших тэгш боломжийг хангах /Лаос/</p>	<p>9. Энэ заалт 2017 оноос хэрэгжиж, тусгай сургуулийн нэг сурагчид 2400 төгрөгөөр үдийн хоол өгч байна.</p> <p>10. Хөгжлийн бэрхшээлтэй оюутны бакалаврын сургалтын зардлыг төрөөс бүрэн хариуцаж байна.</p> <p>11. Боловсролын үнэлгээний төвөөр дамжуулан Элсэлтийн ерөнхий шалгалтанд 2017 онд хамрагдсан 24 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг шалгалтаа өгөх боломж нөхцлөөр ханган дэмжлэг үзүүлсэн бол МУБИС–ийн Боловсрол судлалын сургууль дээр Тусгай хэрэгцээт боловсролын мэргэжлийн тэнхимийг 2017 оны 12 дугаар сард байгуулж үндсэн багш 3, гэрээт 3 багш, 1 арга зүйчтэйгээр үйл ажиллагааг нь эхлүүлэн дэмжлэг үзүүлж байна. Мөн тусгай хэрэгцээт боловсролын хөрвөх 1 жилийн сургалтыг МУБИС, Дорнод их сургууль –ийг түшиглэн зохион байгуулж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургах, суралцуулах, тэдний боловсрол авах боломж нөхцлийг сайжруулах чиглэлээр жил бүрийн төлөвлөгөөнд тусган ажил олгогчийн төлөөлөл, эцэг эхийн холбоотой хамтран ажиллаж байна.</p>
	<p>108.158. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидын эрх, түүний дотор нөхөн үржихүй, хүчирхийллээс ангид байх, хөдөлмөрлөх, боловсрол эзэмших болон шийдвэр гаргах түвшинд оролцох эрхүүдэд онцгой анхаарал хандуулах /Тайланд/</p>	<p>108.152–оос үзнэ үү.</p> <p>– “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай” НҮБ–ын конвенци, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, эрх чөлөөг аливаа ялгаваргүйгээр, бүрэн эдлэх нөхцлийг бүрдүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг салбар дундын зохицуулалтаар хангаж, дэмжлэг үзүүлэх Үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд байгуулж, зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газрын 2016 оны 136 дугаар тогтоолоор баталсан. Зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн чиглэлээр</p>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.158. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидын эрх, түүний дотор нөхөн үржихүй, хүчирхийллээс ангид байх, хөдөлмөрлөх, боловсрол эзэмших болон шийдвэр гаргах түвшинд оролцох эрхүүдэд онцгой анхаарал хандуулах /Тайланд/</p>	<p>ажилладаг төрийн бус байгууллагын төлөөлөл 24 гишүүн багтсан бөгөөд бүх яамдад дэд зөвлөлтэйгээр, 21 аймаг, 9 дүүрэгт салбар зөвлөлтэйгээр ажиллаж байна.</p> <p>– Үндэсний болон дэд салбар зөвлөлүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ–ын төлөөлөл оролцож, тухайн салбар, орон нутгийн хэмжээний бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад оролцох боломжтой болсон. Түүнчлэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын зөвлөлд 2, Сайдын зөвлөхөөр 1 хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах ТББ–ын төлөөлөл ажиллаж байна.</p>
	<p>108.160. Орогнол хүсэгчид буцаахгүй байх зарчмын дагуух эрх болон бусад эрхээ эдлэх бололцоог нь хангах чиглэлээр Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Дээд комиссарын газартай хамтран ажиллах /Уругвай/</p>	<p>Монгол Улс НҮБ–ын Дүрвэгсдийн конвенцид нэгдэж ороогүй. Монгол Улс хүний эрхийг хүндэтгэж, эрхэмлэдэг улс бөгөөд Үндсэн хуульдаа “Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргавал Монгол Улсад орогнох эрх олгож болно” гэж заасан. Мөн Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Дээд комиссарын газартай 2007 онд “Хамтын ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулсан. Энэ баримт бичгийн хүрээнд гарч буй тодорхой асуудал, үүссэн нөхцөл байдалд шаардлагатай арга хэмжээг авч ажиллаж байна. 2018 оны 01 дүгээр сарын байдлаар гаргасан мэдээнд дурдсанаар 2017 онд ХЗДХЯ–нд ирүүлсэн хүсэлтийн дагуу гадаадын 5 дүрвэгчийн асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн. Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Дээд комиссарын газраас 2017 оны 11 дүгээр сард зохион байгуулсан олон улсын дүрвэгсдийн хамгаалалтын асуудлаарх сургалтад ГХЯ, ХЗДХЯ, ХЭҮК, ХХЕГ, ГИХАЭА болон төрийн бус байгууллагууд хамрагдсанаас гадна 2018 оны IV улиралд онцгой байдлын үед дүрвэгсдийн асуудлаар авах арга хэмжээний талаар дотоодын холбогдох байгууллагуудад зориулж ДАЭДКГ–тай хамтран сургалт зохион байгуулахаар ажиллаж байна.</p>

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

<b>№</b>	<b>Зөвлөмж</b>	<b>Хэрэгжилтийн явц</b>
	<p>108.161. Миниматагийн конвенцийг соёрхон батлах асуудлыг судлан үзэж, бичил уурхай эрхлэгчдийн олборлох эрхийг хангах, тэдгээрийн үйл ажиллагааг аль болох хурдан хугацаанд албажуулах зорилгоор Ашигт малтмалын тухай хуулийн бичил уурхайн талаарх 4 дүгээр зүйлийн 4.1.23 дахь заалтыг шинэчлэх /Унгар/</p>	<p>УИХ-аас 2015 онд Мөнгөн усны тухай Минаматагийн конвенцийг соёрхон баталсан.</p> <p>2013–2017 онд Даян дэлхийн байгаль орчны сан /GEF/, НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллагын /UNIDO/ буцалтгүй тусламжийн хүрээнд БОНХАЖЯ /хуучнаар/, НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллагын, БНСУ-ын Миреко нөхөн сэргээлтийн агентлаг хамтран “Монгол улсын химийн бодисын зохистой менежментийг дэмжих замаар хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх мөнгөн усны сөрөг нөлөөллийг бууруулах нь” төслийг хэрэгжүүлсэн. Тус төслийн хүрээнд дараахи үр дүнг гаргаад байна.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Мөнгөн усны талаарх хууль эрх зүйн орчны өнөөгийн байдлын судалгаа, Мөнгөн ус агуулсан хог хаягдлын байгаль орчинд ээлтэй менежментийн талаарх олон улсад мөрдөгдөж буй хууль, журам, стандарт, гарын авлагын судалгаа хийсэн.</li> <li>- Мөнгөн ус агуулсан хог хаягдлын агуулахын стандарт боловсруулсан.</li> <li>- Мөнгөн ус агуулсан бүтээгдэхүүн, хог хаягдлын импорт, экспорт, хил дамжуулан тээвэрлэх, худалдах, ашиглах, хадгалах, устгах үйл ажиллагааг зохицуулах журмын төсөл боловсруулсан.</li> <li>- Мөнгөн ус агуулсан бүтээгдэхүүн, хог хаягдлын байгаль орчинд ээлтэй менежментийн гарын авлага боловсруулсан.</li> <li>- Мөнгөн ус агуулсан эмнэлгийн төхөөрөмжтэй харьцах аюулгүй ажиллагааны гарын авлага боловсруулсан.</li> <li>- Бороо голын мөнгөн усаар бохирдсон хэсэгт мөнгөн ус болон зарим хүнд металлын бохирдлыг тогтоох нарийвчилсан судалгаа хийсэн.</li> <li>- Бороо голын мөнгөн усаар бохирдсон бүс нутгийн хүн ам, мал амьтанд мөнгөн усны бохирдлын нөлөөллийг тогтоох биомониторингийн судалгаа, эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээг хийсэн.</li> </ul>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.161. Миниматагийн конвенцийг соёрхон батлах асуудлыг судлан үзэж, бичил уурхай эрхлэгчдийн олборлох эрхийг хангах, тэдгээрийн үйл ажиллагааг аль болох хурдан хугацаанд албажуулах зорилгоор Ашигт малтмалын тухай хуулийн бичил уурхайн талаарх 4 дүгээр зүйлийн 4.1.23 дахь заалтыг шинэчлэх /Унгар/</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Мөнгөн ус агуулсан хог хаягдлыг түр хадгалах агуулахыг Сонгино-хайрхан дүүргийн 22 хороо, ОБЕГ-ын харьяа Аврах тусгай ангийн хашаанд шинээр барьж байгуулсан.</li> <li>- Мөнгөн усны менежментийн талаарх сургалт, сурталчилгааны материалыг бэлтгэж, “Мөнгөн усны Минаматагийн конвенц болон мөнгөн ус агуулсан бүтээгдэхүүн, хаягдлын байгаль орчинд ээлтэй менежмент” сэдэвт сургалтыг бүх аймгуудын байгаль орчны албад, холбогдох яам агентлагуудын химийн бодис, бохирдлын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулсан 2014 оны 11-р сарын 12-нд зохион байгуулсан. Минаматагийн конвенцоор хүлээсэн үүргээ амжилттай хэрэгжүүлэхэд бодлогын болон хэрэгжилтийн дэмжлэг үзүүлэх зорилгоор Мөнгөн усны суурь үнэлгээ (Minamata Initial Assessment) төслийг 2017 оны 6 сараас хэрэгжүүлж эхлээд байгаа бөгөөд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллагын дэмжлэгээр 2 жилийн хугацаанд хэрэгжүүлэх юм. Энэхүү төслийн хүрээнд дараахь үндсэн 3 үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ:             <ul style="list-style-type: none"> <li>- Мөнгөн усны үндэсний тооллого явуулах – НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрөөс боловсруулсан Мөнгөн усны эх үүсвэр, ялгарлыг тооцоолох аргачлалаар нарийвчилсан тооллогыг явуулна. Тооллогыг 2018 оны 1 сараас эхлэн явуулсан бөгөөд тооллогын тайланг 2018 оны 7 сард эцэслэн хүлээн авна.</li> <li>- Мөнгөн усны эрх зүйн орчинд үнэлгээ хийх – Минаматагийн конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэхэд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомж хэр нийцтэй байгаа, нэмэлт зохицуулалт шаардлагатай эсэхийг тодорхойлох зорилготой. Үнэлгээний тайланг 2018 оны 7 сард тайланг хүлээн авна.</li> <li>- Олон нийтэд мөнгөн усны эх үүсвэр, хор аюул зэргийн талаар мэдээлэл түгээх, мэдлэг олгох замаар ард иргэдийн оролцоог дэмжих хүрээнд 2018 оны 7-р сараас сургалт, сурталчилгааны ажлуудыг хэрэгжүүлнэ.</li> </ul> </li> </ul>

**ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
	<p>108.162. НҮБ–ын Бизнес ба хүний эрхийн Удирдах зарчмуудыг хэрэгжүүлэх үүднээс нүүдэлчин малчдын нөхцөл байдал, эрхээ сэргээлгэх боломжийг сайжруулахад онцгой ач холбогдол өгсөн Үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөг боловсруулах /Нидерланд/</p>	<p>Судалж байна.</p>
	<p>108.163. Олборлох үйлдвэрлэлийн салбарт аюулгүй байдлыг тогтоохдоо хүний эрхийг хангах зорилгоор Аюулгүй байдал, хүний эрхийн санаачилгын талаарх Сайн дурын зарчимд нэгдэх /АНУ/</p>	<p>Судалж байна.</p>
	<p>108.164. Гар аргаар ашигт малтмал олборлож буй иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, байгаль орчныг хамгаалах зорилгоор тус салбар дахь мөнгөн усны хэрэглээг зохицуулсан үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх /Швейцари/</p>	<p>Мөнгөн усны тухай Минаматагийн конвенцийн “С” хавсралтад заасны дагуу алтны бичил уурхайн мөнгөн ус, мөнгөн усны нэгдэлүүдийн хэрэглээ, түүнээс үүдэлтэй бохирдлоос хүний эрүүл мэнд, байгаль орчинг хамгаалах үе шат бүхий Үндэсний төлөвлөгөө (хөтөлбөр)–г олон улсын аргачлалын дагуу боловсруулах ажлыг НҮБ–ын Байгаль орчны хөтөлбөр, Даян дэлхийн байгаль орчны сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байна.</p> <p>“Алтны бичил уурхайгаас үүдэлтэй бохирдлыг бууруулах үндэсний төлөвлөгөө (хөтөлбөр) боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/268 дугаар тушаалаар байгуулсан. Хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд алтны бичил уурхайн салбарын хууль эрх зүй–институцийн хүрээ, нийгэм эдийн засаг, мөнгөн усны тооллого, эрүүл мэндийн чиглэлээр судалгааны баг 2018 онд Баянхонгор аймгийн Баян–Овоо, Галуут, Бөмбөгөр, Жаргалант, Говь–Алтай аймгийн Есөнбулаг, Тайшир, Цогт, Алтай, Чандмань, Булган аймгийн Бүрэгхангай, Төв аймгийн Заамар сумдад ажиллаж, олон улсын аргачлалын дагуу судалгааны мэдээлэл цуглуулсан.</p>

№	Зөвлөмж	Хэрэгжилтийн явц
108.164.	<p>Гар аргаар ашигт малтмал олборлож буй иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, байгаль орчныг хамгаалах зорилгоор тус салбар дахь мөнгөн усны хэрэглээг зохицуулсан үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх /Швейцари/</p>	<p>Үндэсний хөтөлбөрийг 2018 оны 12-р сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулахаар ажиллаж байна.</p> <p>ЗГ-ын 2017 оны 225 дугаар тогтоолоор батлагдсан “Орчны эрүүл мэнд 2” хөтөлбөрийн 3 дахь хэсэгт дараахь заалтуудыг тусган ажиллаж байна:</p> <p>3.6.3.бичил уурхай эрхлэгчид болон тэдний гэр бүлийнхний эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, мэргэжлээс шалтгаалсан өвчинд өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар чиглэлээр:</p> <p>3.6.3.1.бичил уурхай бүхий аймаг, сумын эмч, эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжлээс шалтгаалсан өвчин, осол, гэмтэл, химийн бодисын хордлогыг оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх сургалтад үе шаттайгаар хамруулах;</p> <p>3.6.3.2.бичил уурхай эрхлэгчдийг явуулын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах;</p> <p>3.6.3.3.бичил уурхай эрхлэгч болон тэдний гэр бүлийнхнийг мэргэжлээс шалтгаалсан өвчин, осол, гэмтэл, химийн бодисын хордлогоос урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулах ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна.</p> <p>Хөтөлбөрийн 1, 2-т заасныг хэрэгжүүлэх зорилгоор:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Бичил уурхай эрхлэгчдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах үйл ажиллагааны хүрээнд их эмчийн чадавхийг бэхжүүлэх сургалтыг 2017 оны 11 сарын 09- 10-ны өдөр УБ хотноо зохион байгуулж, сургалтад Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Сэлэнгэ, Увс, Ховд, Төв, Завхан, Өмнөговь зэрэг аймгуудын сум, сум дундын 40 их эмч нар оролцлоо.</li> <li>- 2018 онд бичил уурхай эрхлэгч зонхилдог Төв 1092, Сэлэнгэ 398, Баянхонгор 550 аймгуудад байгаа бичил уурхай эрхлэгчдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулаад байна.</li> </ul>



## 9.7 МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТАЛААРХ ҮНДЭСНИЙ ГУРАВДУГААР ИЛТГЭЛ

Монгол Улс нь 2015 онд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит 2 дахь хэлэлцүүлгийн үеэр 150 зөвлөмжийг хэрэгжүүлэхээр үүрэг амлалт авсан.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газар 2016 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 204 дүгээр тогтоолоор баталсан.

Уг төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг Ерөнхий сайдын 2016 оны 112 дугаар захирамжаар Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ахлуулан байгуулсан. Зөвлөлийн гишүүдээр 11 яамны Төрийн нарийн бичгийн дарга нар, 4 агентлагийн дарга, 8 иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, нарийн бичгийн даргаар Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын дарга болон Хууль зүй, дотоод хэргийн яамны Гэрээ, эрх зүй, хамтын ажиллагааны газрын дарга нар ажиллалаа. Тус зөвлөлийн үндсэн үүрэг бол ерөнхий төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллахын зэрэгцээ явцын дүнг жил бүрийн эхэнд ээлжит хуралдаанаар хэлэлцэж, цаашид авах шаардлагатай арга хэмжээний саналыг биелэлтийн тайлангийн хамт Засгийн газрын хуралдаанд танилцуулахад оршиж байгаа. Орон тооны бус зөвлөл анхны хурлаа 2017 оны 1 дүгээр сард хийж хэрэгжилтийн явцыг сайжруулах зорилгоор яамдын дэргэд дэд зөвлөл байгуулахаар шийдвэрлэн, энэхүү дэд зөвлөлүүдийг яамдын дэргэд байгуулагдан ажиллаж байна. Мөн орон тооны бус зөвлөлийн ээлжит хурлыг жил бүрийн 1 дүгээр сард хийж, дараа сардаа хэрэгжилтийн явцыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлдэг болсон.

### **Хоёр. АРГА ЗҮЙ**

Зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Засгийн газраас баталсны дараа төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудын зөвлөлдөх уулзалтыг 2016 оны 12 дугаар сард зохион байгуулж зөвлөмжийг хэрэгжүүлэх арга замын талаар ярилцсан. Хэрэгжилтийн явцад Засгийн газрын орон тооны бус зөвлөлийн хуралд гишүүний хувьд иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүд оролцож, санал дүгнэлтээ илэрхийлж байсан.

Засгийн газрын зүгээс Хүний эрхийн төрийн бус байгууллагуудын форум болон Хүний эрхийн үндэсний комисстой хамтран бүсчилсэн хэлэлцүүлгийг баруун, зүүн, төв, говийн бүсийн 4 аймагт зохион байгуулсан. Эдгээр хэлэлцүүлэгт нутгийн захиргааны болон орон нутгийн төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллүүд оролцсон бөгөөд Засгийн газар, Хүний эрхийн үндэсний комисс болон Хүний эрхийн ТББ-ын форум тус бүрээс зөвлөмжийн хэрэгжилтийн явцын мэдээллийг танилцуулж хэлэлцүүлгийг өрнүүлсэн. Түүнчлэн Засгийн газраас Хүний эрхийн төрийн бус байгууллагуудын форум, Хүний эрхийн үндэсний комисстой хамтран НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилтийн дунд хугацааны тайлангийн хэлэлцэх зөвлөлдөх уулзалтыг 2018 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгууллаа. Хүний

эрхийн форумаас НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд хүргүүлж байгаа тайланг танилцуулах уулзалтыг 2019 оны 9 дүгээр сард зохион байгуулахад Засгийн газрын байгууллагууд идэвхтэй оролцсон.

### **А. БҮРЭН ХЭРЭГЖСЭН АРГА ХЭМЖЭЭНҮҮД**

**Цаазаар авах ялыг халах чиглэлээр** /Зөвлөмж –108.2, 108.3, 108.22, 108.62, 108.63, 108.64, 108.65, 108.66, 108.67, 108.68, 108.82/:

Монгол Улс нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколоор хүлээсэн үүргийн дагуу Эрүүгийн шинэ хуульд цаазаар авах ялыг ялын төрлөөс хасч хуульчилсан бөгөөд уг хууль 2017 оны 7 дугаар сарын 1–ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.

### **Эрүүдэн шүүхийн эсрэг арга хэмжээ авах чиглэлээр**

/Зөвлөмж – 108.7, 108.35, 108.71, 108.74, 108.75, 108.76, 108.80/ :

Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 23–ны өдөр баталсан. Хуульд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хараат бус үйл ажиллагаагаа явуулах гишүүн болон нэгжийн чиг үүргийг тодорхойлж үндэсний механизмыг бий болгох эрх зүйн орчныг бүрдүүллээ.

Шинэ Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд “эрүү шүүлт тулгах” үйлдлийг гэмт хэрэгт тооцсон.

Одоогийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.9 дүгээр зүйлд Эрүү шүүлт, хүнлэг бус харьцаанаас ангид байх зарчмыг, 16.12 дугаар зүйлд Эрүү шүүлт тулгаж авсан нотлох баримтыг нотлох баримтаар тооцохгүй, харин эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд нотлох баримтаар тооцохоор, мөн хуулийн 6.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт Тагнуул, цагдаа, авлигатай тэмцэх байгууллагын албан хаагчийн үйлдсэн гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах харьяаллыг прокурор тогтоохоор тус хуульчилж өгсөн.

Шүүх, прокурор, цагдаа, авлигатай тэмцэх газар, тагнуул, сэтгэцийн эрүүл мэндийн төв, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гэх зэрэг байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдын сургалтын хөтөлбөрт эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх сэдвийг тусган, албан хаагчдыг тогтмол хамруулж байна. Тухайлбал: Жил бүрийн “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалтын нэгдсэн төлөвлөгөө”–ний дагуу давтан болон мэргэшүүлэх сургалтад эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх гэмт хэргийн талаарх тусгайлсан сургалтыг Хүний эрхийн Үндэсний Комисс болон хүний эрхийн сургагч багшаар бэлтгэгдсэн алба хаагчид тогтмол зохион байгуулж байна. Уг сургалтад 2016 онд 7 удаагийн 14 цагийн сургалтад 331, 2017 онд 8 удаагийн 16 цагийн сургалтад 196, 2018 онд 18 удаагийн 36 цагийн сургалтад 1139 алба хаагч нийт 33 удаагийн 66 цагийн багтаамжтай сургалтад 1666 алба хаагчийг хамруулсан.

Дотоод хэргийн их сургуульд цагдаа, хил, шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон онцгой

байдлын байгууллагын боловсон хүчнийг бэлтгэдэг бөгөөд уг сургуулийн сургалтын хөтөлбөрт хүний эрхийн хичээлийг тусгаж сургалтыг явуулж байна.

Түүнчлэн Монголын Хуульчдын холбооны хуульчийн үргэлжилсэн сургалтын хүрээнд зохион байгуулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ба хүний эрх сургалтад нийт 120 хуульч хамрагдсан байна.

Мөн Төрийн албаны шинэ хууль /2018/ –д заасан мэргэшүүлэх сургалтын агуулга хөтөлбөрт хүний эрхийн хичээлийг шинээр оруулан төрийн албаны бүх шатны албан хаагчдыг сургалтад хамруулж байна.

Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй нийт **26** цагдан хорих байраас 2016 оноос өмнө **11**, 2016 оноос хойш **8**, нийт **19** цагдан хорих байрыг шинээр барьж, **7** цагдан хорих байрыг шаардлагад нийцүүлэн засварласан. Шинээр баригдсан болон урсгал засвар, тохижилт хийгдсэн цагдан хорих байрууд НҮБ–аас баталсан “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”–ийн 9 дүгээр зүйлд заасан хорих өрөө, тасалгаанд тавигдах үндсэн шаардлагыг бүрэн хангаж байна. “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль”–д зааснаар 1 хүнд ногдох талбайн хэмжээ 2.5 м/кв байхаас шинээр ашиглалтад орсон хорих өрөөний талбайн хэмжээ дунджаар 3–3.5 м/кв болж нэмэгдэн, байгалийн гэрэл чөлөөтэй тусгах, агаарын солилцоо бүрэн явагдах нөхцөлийг хангаад байна.

**Гурав. Хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон ахмад настан зэрэг хүн амын эмзэг бүлгийн гишүүдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр** /Зөвлөмж 108.146, 108.147, 108.148, 108.149, 108.152, 108.153, 108.154, 108.155, 108.156, 108.157, 108.158/

Хүний эрх, хөгжил, хамгааллын хүрээнд Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай, Ахмад настны тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиуд болон Хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, хөгжил, оролцоог дэмжих үндэсний хөтөлбөр, Залуучуудын болон ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр, Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг тус тус батлан хэрэгжүүлж байна. Хүн амын бүлгүүдийн эдгээр хуульд хүний язгуур эрхийг хамгаалж, хүнийг нийгмийн амьдралд эрх тэгш оролцох зарчимд суурилан, ялгаварлан гадуурхахыг хориглосон.

Үндэсний статистикийн хорооны 2018 оны жилийн эцсийн мэдээгээр Монгол Улсад нийт 105.6 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаагийн 47,0 мянга нь төрөлхийн, 58,7 мянга нь олдмол бэрхшээлтэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 10.8 хувь нь харааны, 11.9 хувь нь хэл яриа, сонсголын, 20.4 хувь нь хөдөлгөөний, 19.2 хувь нь сэтгэцийн, 6.8 хувь нь хавсарсан бэрхшээлтэй байна. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрыг 2018 онд байгуулан ажиллаж байна.

Засгийн газрын 2016 оны 200 дугаар тогтоолоор хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоон, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, хяналт тавих

чиг үүрэг бүхий Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссыг байгуулан, 21 аймаг, 9 дүүрэгт салбар комисстойгоор үндэсний хэмжээнд ажиллаж байна.

Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газартай хамтран 250 хүүхдийг хэвтүүлэн эмчлүүлэх, 250 хүүхдэд өдрөөр сэргээн засах хөгжлийн үйлчилгээ үзүүлэх хүчин чадалтай “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв”-ийн 2019 оны 5 дугаар сар ашиглалтад оруулан үйлчилгээ үзүүлж байна. Мөн БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай тоноглол бүхий спорт, цогцолбор”-ийг 2021 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Цаашид Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр Ховд, Хөвсгөл, Дорнод, Дундговь, Архангай, Дархан-Уул зэрэг 6 аймагт бүсчилсэн хөгжлийн төвүүдийг 2021 онд байгуулж дуусна.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд болон Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/304, А/699, А/460 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар”-т хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамрагдахад хэрхэн дэмжлэг үзүүлэх тухай, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуульд элсүүлэх үйл явцын талаар дэлгэрэнгүй тусгасан нь үр дүнгээ өгч байна.

Хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт хандлагыг өөрчлөх зорилгоор “Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл”-ийн хүрээнд Монгол Улсад анх удаа “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын сургалт”-ыг зохион байгуулах үндэсний хэмжээний 41 сургагч багш бэлтгэсэн. Сургагч багш нар нь бүгд хөгжлийн бэрхшээлтэй иргэд бөгөөд өөрсдийн бэрхшээл дээрээ үндэслэн бусдад ойлголт, хандлага өгдгөөрөө бусад сургалтаас онцлогтой юм. Тус сургалтыг 2017 оноос хойш нийтдээ 300 гаруй удаа зохион байгуулж, 10200 гаруй хүнийг хамруулаад байна.

Үндэсний статистикийн хорооны 2018 оны мэдээгээр 0–18 насны 10663 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна. Эдгээрээс 6518 хүүхэд ЕБС-д үүнээс 1740 хүүхэд тусгай сургуульд суралцаж байна. Сургуулийн өмнөх насны /2–5/ хөгжлийн бэрхшээлтэй 1585 хүүхэд байгаагаас 2019–2020 оны хичээлийн жилд цэцэрлэгт хамрагдсан 1076 хүүхэд байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас 2021–2030 он хүртэл хэрэгжүүлэх Боловсролын Мастер төлөвлөгөөг боловсруулж дуусч байгаа бөгөөд энэхүү Мастер төлөвлөгөөнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах талаар тусган ажиллаж байна. Мөн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын тушаалаар холбогдох 10 журмыг баталсан ба 3 стандартыг батлуулаад байна. Тухайлбал: БСШУС-ын сайдын 2019 оны А/292 дугаар тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах” журам батлагдсан бөгөөд хэрэгжүүлэх зөвлөмжийг боловсруулан ажиллаж байна.

2018–2019 оны хичээлийн жилд Японы Жайка олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн төслийн хүрээнд шаардлагатай гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүнийг 29,7 мянган хувийг хэвлэн улсын хэмжээний бүх сургууль, насан туршийн боловсролын

төвүүдэд хүргүүлэн сургалтад ашиглаж байна. Мөн ерөнхий боловсролын оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөөнүүдийг шинэчлэн баталж, сургалтыг зохион байгуулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд үзүүлэх нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч “Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрт тусган, ДЭМБ–ын дэмжлэгтэйгээр хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйн үзлэгийн орыг нийслэлийн амаржих газар, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд суурилуулсан бөгөөд 2020 онд бүх аймгуудад нийлүүлэхээр ажиллаж байна.

УИХ–аас Авто замын тухай хуулийг 2017 онд шинэчлэн баталж, хуульд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих эрхийг хангаж авто зам, замын байгууламж ашигласны төлбөрөөс чөлөөлөх эрх зүйн орчинг бүрдүүлсэн. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 49 дүгээр тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам”–д “Авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан байгууллагын төлөөлөл орох эрх зүйн орчныг бүрдүүлээд байна.

Нийтийн тээврийн үйлчилгээний 1207 тээврийн хэрэгсэл бүртгэлийн санд бүртгэлтэй байгаагаас 56 тээврийн хэрэгсэл хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх нам шалтай, зориулалтын шаттай байгаа нь нийтийн тээврийн хэрэгслийн дөнгөж 4.6 хувийг эзэлж байна. Цаашид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ахмад настан, хүүхэд, эмэгтэйчүүдэд хүртээмжтэй нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор “Төрөөс Автотээврийн салбарт баримтлах бодлого (2018–2026)”–ын баримт бичгийг Засгийн газрын 2018 оны 321 дүгээр тогтоолоор баталсан.

Монгол–Оросын “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэг нь өөрсдийн зардлаар Зорчигчийн 482–р вагоныг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан MNS 5876:2012 стандартын дагуу тоноглож хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг саадгүй, бие даан тухтай зорчих боломжийг бүрдүүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон хүн амын эмзэг бүлгийн эрхийг хамгаалах талаарх ойлголт, хандлага өөрчлөгдөж, зам, тээврийн салбарын үйлчилгээг тэдгээрт шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал: Хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээний автобусанд ХБИ, ахмад настан, 3 хүртэлх насны хүүхэдтэй хүмүүс, жирэмсэн эхчүүдэд зориулсан суудлын таних тэмдгийг автобусны 1, 2 дугаар суудалд байршуулсан бөгөөд [www.transdep.mn](http://www.transdep.mn) сайтад байрлах онлайн тасалбар захиалгын системд уг суудлыг сонгох боломжийг олгосон.

### **Эх нялхсын эндэгдлийг бууруулах нь**

Монгол Улс 1990 онд 100,000 амьд төрөлтөд 199 байсан эхийн эндэгдлийг 2015 онд 100,000 амьд төрөлтөнд 26 болгон дөрөвний гурваар бууруулж, мөн тав хүртэлх насны хүүхдийн болон нялхсын эндэгдлийг 1990 оны түвшинг 2015 оны түвшинтэй харьцуулахад 4 дахин бууруулж, “Мянганы хөгжлийн зорилтыг хангасан” дэлхийн 9 орны нэг болж чадсан билээ.

Энэхүү амжилтад хүрэхэд Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлсэн бодлого,

шийдвэрүүд чухал үр дүнтэй байсныг тэмдэглэж байна. Тухайлбал: “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр (2012–2016), “Эх, нярайн эрүүл мэнд стратеги” (2011–2015), “Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг хэрэгжүүлэх стратеги” (2014–2020), “Нярайн тандалт шинжилгээний хөтөлбөр” (2014–2020), “Хүүхдийг эхийн сүүгээр хооллох”, “Хүүхдийн өвчний цогц менежмент”, “Дархлаажуулалтын өргөжүүлсэн хөтөлбөр”, “Хүүхэд хөгжил, хамгаалал” үндэсний хөтөлбөр, “Эх, нярайн эрүүл мэндийг сайжруулах үндэсний стратеги”, “Хүүхдийн эсэн мэнд амьдрахуй” стратеги зэрэг бодлогын баримт бичгүүдийг боловсруулан, шат дараатайгаар хэрэгжүүллээ.

Гэр бүл төлөвлөлтийн тусламжийн хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх зорилгоор улсын төсвөөс жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгсэлд зарцуулах зардал 2009 онд 85 сая төгрөг байсныг жил дараалан нэмэгдүүлж, 2019 онд 1.8 тэрбумд хүргэж, эмэгтэй бүр гэр бүл төлөвлөлтийн тусламж үйлчилгээг өрх сум, тосгоны эрүүл мэндийн төвөөсөө авах боломжийг бүрдүүллээ.

Монгол Улсын нутаг дэвсгэрийн алслалтаас шалтгаалж, эх, хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээ хожимдох эрсдлийг бууруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газар, Люксембургийн Засгийн газар, НҮБ-ын Хүн амын сан хамтран “Эх, нярайн зайн оношилгоо”-ны төслийг хэрэгжүүлж, 21 аймгийг ЭХЭМҮТ-тэй сүлжээнд холбож, зайн оношилгооны тоног төхөөрөмж, сургалтын багцаар хангаж, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг багаар нь сургалтад хамрууллаа.

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд үзүүлэх нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч “Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрт тусган, ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйн үзлэгийн орыг нийслэлийн амаржих газар, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд суурилуулсан бөгөөд 2020 онд бүх аймгуудад нийлүүлэхээр ажиллаж байна.

“Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай” хууль баталсан нь хүүхдийн 6 сар хүртэл нь дан хөхөөр хооллох, хөхний сүү орлох бүтээгдэхүүн нийлүүлэлт, зар сурталчилгааг хязгаарлах ач холбогдолтой бодлогын баримт бичиг юм.

Төрөөд нэг цагийн дотор ангир уургаа амласан хувь 96.1; товлолт дархлаажуулалтын хамралт 98.0 хувьтай байгаа нь сэргийлж болох халдварыг бууруулж чадсан.

Дархлаажуулалтын хууль болон Дархлаажуулалтын өргөжүүлсэн хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд дархлаажуулалтын хамралтыг 98 хувьд хүргэж, сүүлийн 10 жилд сахуу, нярайн татран, хөхүүл ханиад өвчлөл бүртгэгдээгүй, гепатитийн А вируст халдвар 1.5 дахин, гахай хавдар өвчнийг 4.2 дахин буурууллаа.

Хүүхдийн хатгалгаа өвчнөөс сэргийлэх пневмококкийн эсрэг вакциныг зорилтот бүлгийн хүүхдэд хийж эхэлсэн бөгөөд уг вакциныг Дархлаажуулалтын сангаас санхүүжүүлж нийлүүлэхээр шийдвэрлэсэн.

Эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулан, ажиллаж байна. Тухайлбал. 2–12 насны хүүхдийн шүдийг эрүүлжүүлэхэд хувийн хэвшлийн 153 эрүүл мэндийн байгууллагын татан оруулж, 2019 онд улсын төсвөөс 5,3 тэрбум төгрөгийг зарцуулан энэ насны 93,495 хүүхдийг амны хөндийн урьдчилан сэргийлэх, эмчлэн эрүүлжүүлэх тусламж, үйлчилгээнд хамруулан эрүүл шүдтэй болголоо.

Дээрх бодлого, үйл ажиллагааны үр дүнд:

- Эхийн эндэгдэл жил бүр буурч, 2019 онд 100000 амьд төрөлтөд 23.0 болж, өмнөх онтой харьцуулахад 3 тохиолдлоор буюу 4.1 пунктээр буурснаар Монгол Улсын “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”-ын нэгдүгээр үе шат (2016–2020) оны шалгуур үзүүлэлтэд “Эхийн эндэгдлийн түвшинг 100000 амьд төрөлтөд 25 болгож бууруулна” гэсэн зорилтыг хангаж чадсан байна.
- Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1000 амьд төрөлтөд 16.1 болгон бууруулж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 48 тохиолдлоор буюу 1000 амьд төрөлтөд 0.8-оор буурсан байна.

#### **Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр**

/Зөвлөмж–108.87, 108.93, 108.102, 108.104/ :

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг 2016 онд баталсан. Уг хуулийг дагаж гарах 33 журам, 2 стандартыг батлан хэрэгжүүлж байна. Мөн энэхүү хуулиар үүрэг хүлээгчдийн үзүүлэх үйлчилгээний стандарт, арга зүй, үйл ажиллагааны гарын авлага зэргийг боловсруулан, тараасан.

Эрүүгийн хуулийн 4.4, 10.4, 11.7, 12.1, 13.13, 15.3, 16.4 дүгээр зүйлд Гэр бүлийн хүчирхийлэл, гэрлэлтийн хүчин, бэлгийн дарамтыг эрүүгийн гэмт хэрэгт тооцон тус тус хуульчилсан.

#### **Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр**

/Зөвлөмж–108.8, 108.83, 108.106, 108.108, 108.113/:

УИХ–аас Хүүхдийн эрхийн тухай конвенцийн Мэдээлэл хүргүүлж, хэлэлцүүлэх журмын тухай нэмэлт протоколыг 2015 оны 4 дүгээр сарын 16–ны өдөр соёрхон баталсан.

Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиар хүүхдийн бие махбодийн шийтгэлийг эрс хориглосон.

Шинэ Эрүүгийн хуульд хүүхдийн эсрэг гэмт хэргийг тусгайлан бүлэг болгон тусгасан бөгөөд хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэхийг гэмт хэрэгт тооцон хуульчилсан.

Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар бүлэгт Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг тусгайлан зохицуулсан.

Хөдөлмөрийн сайдын тушаалаар 2016 оны А/36 дугаар тушаалаар батлагдсан “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”–д гар аргаар алт олборлох, өнгөт болон хагас үнэт чулуу олборлох болон бусад төрлийн ашигт малтмал олборлох үйл ажиллагаа, уул уурхайн туслах үйл ажиллагаанд хүүхэд хөдөлмөр эрхлэхийг хориглосон. Мөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”–д Бичил уурхай эрхлэгч этгээд нь 18 нас хүрсэн Монгол Улсын иргэн байх гэсэн заалтыг тусган хэрэгжилтэд хяналт тавьж байна.

#### **Хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр** /Зөвлөмж – 108.118, 108.120/

Эрүүгийн шинэ хуулийн 16.6 дугаар зүйлд Хүүхэд худалдаалах, 13.1 дүгээр зүйлд Хүн худалдаалах үйлдлийг гэмт хэрэгт тооцсон. Хүн худалдаалах гэмт хэрэгт ялын

хэмжээг 2 жилээс бүх насаар нь хорих, хүүхэд худалдаалах гэмт хэрэгт ялын хэмжээг 13.1 дүгээр зүйлд заасан шинжгүй бол 2–8 жил хорихоор тусгасан байна.

**Ялгаварлан гадуурхах бүх хэлбэр, тэр дундаа ЛГБТ хүмүүсийг ялгаварлан гадуурхахтай тэмцэх чиглэлээр /Зөвлөмж – 108.55, 108.56/**

Шинэ Эрүүгийн хуульд ялгаварлан гадуурхахыг гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан. Уг хуульд ялгаварлан гадуурхах гэмт хэргийг тусгахдаа “бэлгийн болон хүйсийн чиг баримжаагаар” ялгаварлан гадуурхах үйлдлийг хамруулахаар заасан бэлгийн болон хүйсийн чиг баримжаа өөр хүний эрхийг хамгаалах маш том хууль зүйн хөшүүрэг болсон. Мөн эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд боловсруулж батлуулсан бүх хуульд дээр дурдсан асуудлаар ялгаварлан гадуурхаж болохгүй гэсэн тусгай зарчмыг тусгасан. Хэрэв хууль зөрчиж ялгаварласан тохиолдолд гомдол хүсэлтээ гаргах, шийдвэрлүүлэх нөхцөл боломж хуульчлагдсан болно.

**Олон улсын гэрээнд нэгдэн орох, дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх, хүний эрхийн гэрээний хэрэглээг сайжруулах, сургалт зохион байгуулах чиглэлээр /**

**Зөвлөмж – 108.37, 108.38, 108.39, 108.40, 108.161, 108.163, 108.164/**

Монгол Улс НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганаар “Хөдөөгийн охид, эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах тухай”, “Бичиг үсгийн боловсролын тухай” “Ардчиллын боловсролын тухай” тогтоолын санаачлагчийн зэрэгцээ Хүний эрхийн зөвлөлийн “5 хүртэлх насны хүүхдийн урьдчилан сэргийлж болохуйц эндэгдэл болон өвчлөл” тогтоол, “Цаазаар авах ялын тухай” тогтоолын санаачлагчдын бүлэгт ажиллаж байна.

Монгол Улс цаазаар авах ялыг халахад чиглэсэн олон улсын хамтын нийгэмлэгийн хүчин чармайлтыг дэмжиж, хувь нэмрээ оруулахыг эрмэлзэж ирлээ. Монгол Улс Цаазын ялын эсрэг Олон улсын Хороог Дэмжих бүлгийн гишүүнээр идэвхтэй ажиллаж байгаагаас гадна Европын Холбоо, Аргентиний талтай хамтран “Цаазаар авах болон эрүүдэн шүүхэд ашигладаг бүтээгдэхүүний худалдааг хориглох Дэлхий нийтийн холбоо” санаачилгыг 2017 оноос эхлүүлэв.

Монгол Улс 2016–2018 онд Хүний эрхийн зөвлөлийн гишүүнээр анх удаа ажиллав. Энэ хугацаанд иргэний нийгмийн орон зайг хамгаалах, хүний эрхийг хамгаалагчид болон хүний эрхийн үндэсний байгууллагыг дэмжих, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх мөн бэлгийн чиг хандлага, жендэрээс үүдэлтэй ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх, Хүний эрхийн зөвлөлийн тусгай процедур, мандат эзэмшигчидтэй хамтран ажиллах, цаазын ялыг халах, хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн төлөө идэвхтэй байр суурь баримталж ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн хэрэгжилтийн тухай анхны тайлангаа 2010 онд, удаах тайланг 2016 онд НҮБ-ын Эрүү шүүлтийн эсрэг хороогоор тус тус хэлэлцүүлсэн ба Хорооны зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлан, ажиллаж байна. Тус конвенцийн нэмэлт протоколд 2015 онд нэгдэн орсон. Мөн Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколын Дэд



хороо /ОРСАТ/-той Засгийн газар тогтмол, нээлттэй харилцаж, хамтран ажиллаж ирэв. Дэд хорооны төлөөлөгчид 2017 оны 9 дүгээр сард Монгол Улсад ажиллаад Засгийн газарт зөвлөмж өгсөн. Уг зөвлөмжийг хэрэгжилтийн явц, гарсан ахиц өөрчлөлтийн талаар Дэд хорооны гишүүдтэй Засгийн газраас 2019 оны 6 дугаар сард видео хурал хийж танилцуулсан. Мөн ГХЯ, ХЗДХЯ, НҮБ-ын ХЭДКА-тай хамтран Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг байгуулах асуудлаар зөвлөлдөх уулзалтыг 2018 оны 10 дугаар сард Улаанбаатар хотод зохион байгуулахад Дэд хорооны орлогч дарга Виктор Захариа оролцсон.

Монгол Улс Хүний эрхийн зөвлөлийн олон улсын гэрээний хэрэгжилтийг хангах чиг үүрэгтэй тусгай процедур, мандат эзэмшигчдэд 2004 онд нээлттэй урилга хүргүүлсэн. Тайлангийн хугацаанд Эрүүл, аюулгүй, цэвэр, тогтвортой орчинд амьдрах эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч (2017), Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах эрхийн асуудлаарх Тусгай илтгэгч (2018), Хүний эрхийн хамгаалагчийн асуудал хариуцсан НҮБ-ын Тусгай илтгэгч (2019), Улсын гадаад өр болон холбогдох бусад санхүүгийн үүргийн хүний эрх, тэр дундаа эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ бүрэн эдлэхэд үзүүлэх нөлөөллийн асуудал хариуцсан Бие даасан шинжээч (2019) онд Монгол Улсад тус тус ажиллалаа. Хүний эрхийг хамгаалагчийн асуудал хариуцсан НҮБ-ын Тусгай илтгэгч М.Форст 2019 оны 4 сард Монгол Улсад хийсэн айлчлалынхаа дараа дахин 9 дүгээр сард ирж “Хүн бүр хүний эрхийн хамгаалагч–Эрх зүйн баталгааг хангах нь” зөвлөлдөх уулзалт, сэтгүүлчдэд зориулсан кино хэлэлцүүлэг, мөн олон нийтийн лекц зэрэг нөлөөллийн ажилд оролцсон нь Засгийн газар хүний эрхийн гэрээний хэрэгжилтийг хангах чиг үүрэгтэй НҮБ-ын тусгай процедур, мандат эзэмшигчидтэй тууштай хамтран ажиллаж байгаагийн нэг илрэл боллоо гэж үзэж байна.

“Аюулгүй байдал, хүний эрхийн Сайн дурын зарчмын санаачилга”-ын талаар өргөн хүрээнд судалгаа хийж, холбогдох байгууллагуудын оролцоотой хэлэлцүүлэг зохион байгуулсан. Монгол Улс НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс өгсөн зөвлөмжийн дагуу “Бизнес ба хүний эрхийн чиглэлээр баримтлах удирдах зарчмууд”-ыг хэрэгжүүлэх үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахаар ажиллаж байгаа бөгөөд энэ төлөвлөгөөнд “Аюулгүй байдал, хүний эрхийн сайн дурын зарчим”-аас шаардлагатай элементүүдийг тусгах, харин санаачилгын цаашдын өрнөлийг ажиглах нь зүйтэй гэсэн байр суурьтай байгаа болно.

Монгол Улс нь Мөнгөн усны тухай Минаматагийн конвенцийг 2015 онд соёрхон баталсан бөгөөд Засгийн газрын 2019 оны 317 дугаар тогтоолоор “Алтны бичил уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй мөнгөн усны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг олон улсын байгууллага, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр батлан хэрэгжүүлж эхлээд байна.

### **Хүний эрхийн Үндэсний Комиссын мандатыг бэхжүүлэх чиглэлээр**

/Зөвлөмж – 108.25, 108.28, 108.29, 108.30, 108.31, 108.32, 108.33/:

Шинээр баталсан Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах ажиллагааг Парисын зарчимд нийцүүлэн комиссын гишүүний тоог 3 байсныг 5 болгон, сул орон тоон дээр

нээлттэй сонгон шалгаруулалт явуулах, үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх хангалттай төсөвтэй байхаар, Комисст гаргасан гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гишүүнийг комиссоос хүргүүлж буй шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг биелүүлэхгүй удаашруулах, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох талаар шуурхай, тодорхой арга хэмжээ авахгүй байгаа нь илэрхий байгаа тохиолдолд хариуцлага хүлээлгэх гэх зэрэг олон зохицуулалтыг нарийвчлан тусгасан.

## **Б. ХЭРЭГЖИЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭНҮҮД**

### **Хоёр. Эрүүдэн шүүхийн эсрэг арга хэмжээ авах чиглэлээр**

*/Зөвлөмж 108.7, 108.72, 108.73, 108.76, 108.77, 108.79, 108.126, 108.127/:*

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд Улсын Ерөнхий прокурорын 2017 оны А/57 дугаар тушаалаар баталсан “Мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлага” журмын дагуу 2019 оны 12 дугаар сарын байдлаар мэдүүлэг авах нийт 334 өрөөг ашиглаж байна. Эдгээр өрөөнүүдийг дуу, дүрсний бичлэгээр бэхжүүлэх төхөөрөмжөөр тоноглож, бичлэгийг устгах, засварлахаас урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээлэл хадгалах серверийг тусгай өрөөнд байрлуулж, хэвийн үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны Б/444 дүгээр тушаалаар Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийг байгуулж, 30 алба хаагчийн орон тоотой үйл ажиллагаа явуулж байна. Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааны хүрээнд 2016–2019 онд нийт 244 хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлж, 276 иргэнийг хамгаалалтад авсан. Хамгаалалтад авагдсан гэрч, хохирогчдоос 2019 онд эрүүдэн шүүсэн байж болзошгүй гэмт хэргийн гэрч 3, хамаарал бүхий 1 иргэн байсан бөгөөд хамгаалалтын арга хэмжээний явцад ямар нэгэн аюул, эрсдэл учирсан тохиолдол байхгүй байна. Хамгаалалтад авагдсан гэрч, хохирогчид хууль зүйн болон сэтгэлзүйн, мөн гэмт хэргийн улмаас эрүүл мэнд нь хохирсон бол эрүүл мэндийн туслалцааг тус тус төрөөс үнэ төлбөргүй үзүүлдэг.

Прокурорын дэргэд Мөрдөн байцаах албыг сэргээн байгуулах асуудлыг судалж байна.

Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21<sup>3</sup> дугаар зүйлд “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”-гийн үйл ажиллагааг зохицуулж өгсөн. Уг сангаас эрүү шүүлт тулгах болон бусад гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, түүнчлэн хүнд гэмтэл учирсан хохирогчийн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрт заасны дагуу эмчилгээний зардал, оршуулгын зардал, хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулан нөхөн төлбөр олгож байна.

Шүүхийн шинжилгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар ХЗДХЯ-аас хуулийн төслийг боловсруулж байна. Уг төсөлд Сэтгэл санааны хохирлыг тооцох аргачлалыг батлах эрх бүхий этгээдийг тодорхойлсон бөгөөд тухайн аргачлалаар иргэний сэтгэл санааны хохирлыг мөнгөн дүнгээр тооцон хохиролыг барагдуулах боломжтой болно.

**Гурав. Хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон ахмад настан зэрэг хүн амын эмзэг бүлгийн гишүүдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр /**

*Зөвлөмж 108.24, 108.34, 108.43, 108.143/*

Монгол Улсын хүн амын тоо 2018 оны байдлаар 3.2 сая, хүн амын жилийн дундаж өсөлт 1.9 хувь, нэг эмэгтэйн амьдралынхаа туршид төрүүлж буй хүүхдийн тоо 2.9, хүн амын төрөлтөөс тооцсон дундаж наслалт 70.2 жил байна. Дэлхийн 232 орноос хүн амын тоогоороо 136, төрөлтийн түвшнээрээ 66, дундаж наслалтаараа 143-т эрэмбэлэгдэж байна.

Нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, хүн амын насны бүтцийн хэтийн төлөвийг харгалзан Нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг хийх, зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг илүү боловсролгүй болгох, цалин хөлс, хөдөлмөрийн харилцааны оновчтой тогтолцоог хөгжүүлэх, хөдөлмөрлөх таатай орчныг бүрдүүлэх зэрэг хүний амьдралын чанарыг сайжруулах чиглэлээр тодорхой бодлогыг хэрэгжүүлсэн.

Манай улсын ядуурлын түвшин 2014 оны 21.6 хувиас 2016 онд даруй 8 пунктээр өссөн бол 2018 онд 28,4 хувьтай байна. Тогтвортой хөгжлийн зорилтын 1 дэх заалт буюу ядуурлыг устгах зорилтод хүрэхэд ихээхэн хүндрэл тулгарч байгаад Засгийн газар анхаарч, 2019 онд 4 дүгээр сард Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг баталж, хэрэгжилтийг хангах, салбар дундын уялдааг ханган ажиллаж байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнд үзүүлэх төрийн үйлчилгээ, дэмжлэгийг илүү зорилтот бүлэгт чиглүүлэх, дэмжлэгийн хэмжээг эдийн засаг, иргэдийн амьжиргааны түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүллээ.

*Хүүхдийн мөнгө, нийгмийн халамжийн үйлчилгээ*

Хүн амын тогтвортой өсөлтийг хангах, төрөлтийг дэмжих бодлого нь Монгол Улсын төрийн бодлогын үндсэн зорилтын нэг юм. Нийгмийн халамжийн тухай хууль, Олон хүүхэд төрүүлж, өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль, Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай зэрэг хуулийн хүрээнд эх, хүүхдэд чиглэсэн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Тухайлбал, Нийгмийн халамжийн тухай хуульд заасан нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүнд чиглэсэн хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг 2013 оноос эхлүүлэв. Энэ үйлчилгээнд 26.5 мянган өрхийн 143.3 мянган иргэн хамрагдаж, жилд 17.9 тэрбум төгрөг зарцуулж байна.

Нийт хүн амын тоонд ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хүн амын эзлэх хувь 2018 онд 28.4 хувьтай байгаа эдийн засгийн энэ нөхцөлд ядуурлын шугамын доор байгаа зорилтот өрхийн нийгмийн хамгааллын зардлыг нэмэгдүүлснээр тэднийг орлогын ядууралд өртөхөөс хамгаалах бодлогыг баримтлан ажиллав. Энэ үйлчилгээнд 2015 онд нийт өрхийн 2,9 хувь, нийт хүн амын 4,4 хувь хамрагдсан бол 2018 онд нийт өрхийн 5,3 хувь, нийт хүн амын 8,0 хувь болж, хамрагдалт 2 дахин нэмэгдэж, хүнсний талоны өртгийг 20 хүртэл хувиар өсгөж нийт 37,6 тэрбум төгрөг зарцууллаа. Нийгмийн халамжийн үйлчилгээг өргөжүүлэх бодлогын хүрээнд 2020 онд уг үйлчилгээнд 42.2 тэрбум төгрөг улсын төсөвт туссан.

Засгийн газар эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлд зорилтот өрхийн нийгмийн хамгааллын зардлыг бууруулахгүй байх зорилго тавьж 2016 оноос хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хамрагдалтыг үе шаттай нэмэгдүүлсэн. Өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн өрхийн босго оноог 2016 онд 502.567, 2017 онд 554, 2019 оноос 670 болгон нэмэгдүүлж, эдгээр өрхийн 0–18 хүртэлх насны хүүхдэд хүүхдийн мөнгө олгож байна.

Он	Нийт хүүхдэд эзлэх хувь	Төсөв /тэрбум төгрөг/
2016	80,9	218,8
2018	77,2	209,4
2019	85,0	229,8
2020	Судалгаанд хамрагдсан бүх хүүхэд	240,0

✓ **Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах**

➤ **Нийгмийн халамжийн үйлчилгээ**

Олон хүүхэдтэй өрхийн амьжиргааг дэмжих, хүүхдээ гэртээ асарч байгаа эхчүүдийн нийгмийн баталгааг дээшлүүлж, хүн амаа өсгөх бодлогыг хүн амын цонх үед хэрэгжүүлэх нь нэн чухал байна. Хүн амын өсөлтийг дэмжих зохистой бодлого хэрэгжүүлэх, эх, хүүхдийн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудлыг бодлогын хувьд уялдаатай авч үзэх, холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шаардагдах төсөв санхүүжилтийг тооцоо судалгаанд үндэслэн нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа үзүүлж байна. Тухайлбал,

Улсын Их Хурлаас Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийг 2017 онд баталж, 2018 оноос дагаж мөрдөж байна. Хуулийн дагуу:

- Хүүхдийн тархины болоод биеийн өсөлт хөгжилд төрснөөс хойшхи эхний 1000 хоногт авсан шимт хоол тэжээл, асаргаа сувилгаа чухал байдаг. Иймд 0–3 хүртэлх насны хүүхэд асарч байгаа 159622 эхчүүдэд сар бүр 50.0 мянган төгрөгийн мөнгөн тэтгэмж олгоход жилдээ 91,5 тэрбум төгрөг;
- 0–18 насны 3 болон түүнээс дээш хүүхэдтэй 6.1 мянган өрх толгойлсон эх /эцэг/-д улиралд 320.0 мянган төгрөг, нийт 5.8 тэрбум төгрөг /2020 оноос 420,000 төгрөг/;
- Жирэмсний таван сартайгаас эхлэн хүүхэд төрүүлэх хүртэлх хугацаанд 95.404 эхэд сар бүр 40.000 төгрөгийн тэтгэмж олгоход жилдээ 12.1 тэрбум төгрөг;
- Дөрөв хүртэлх насны ихэр хүүхэд төрүүлсэн эхэд 2 ихэр хүүхэд тус бүрт 1.0 сая төгрөг, 3 болон түүнээс дээш хүүхэд тус бүрт 3.0 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг 815 хүүхдэд олгоход жилдээ 1.5 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан.

Дээрх хууль хэрэгжиж эхэлснээр хүүхдээ эрүүл өсгөн бойжуулах, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд бүрэн хамруулах зэргээр тодорхой үр дүнтэй арга хэмжээ болсон гэж олон улсын байгууллагууд үзэж байна.

➤ **Нийгмийн даатгал**

Эмэгтэйчүүд, эхчүүдийн эрхийг хамгаалах, нийгмийн баталгааг хангах хүрээнд эрэгтэй, эмэгтэй хүн тэтгэвэр тогтоолгох насыг 65 болгох, ингэхдээ тэтгэврийн насыг аажмаар буюу жилд 3 сараар хойшлуулан тэтгэвэр тогтоох эрх зүйн шинэчлэлийг хийж, 2019 оноос мөрдөж байна.

Олон хүүхэд төрүүлж, өсгөсөн эхчүүдийн хөдөлмөрийг бодитой үнэлж, төрүүлж, өсгөсөн хүүхэд тус бүрийн тоогоор 1 жил 6 сарыг улсад ажилласан жил, нийгмийн даатгал төлсөн хугацааг нэмэгдүүлэн тооцохоор шийдвэрлэж 2020 оны 1 дүгээр сараас хэрэгжүүлж эхлээд байна.

Хүүхдээ 3 нас хүртэл нь өөрийн биеэр асарч байгаа даатгуулагч эхийн хүүхдээ асрах хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийг тэтгэмжийн даатгалын сан болон улсын төсвөөс хариуцан төлөх эрх зүйн орчинг бүрдүүлэв. Үүнд:

- Сайн дурын даатгалд даатгуулсан эх хүүхэд төрүүлээд, хүүхдээ 3 нас хүртэл асарч хүмүүжүүлж байгаа бол энэ хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийг тэтгэмжийн даатгалын сангаас, 50 хувийг эх өөрөө төлнө.
- Ажил эрхэлдэггүй бусад ээж төрөөд, хүүхдээ 3 нас хүртэл өөрөө өсгөж байгаа бол энэ хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийг төр хариуцаж, 50 хувийг даатгуулагч эх өөрөө төлөх зохицуулалт хийсэн.
- Даатгуулагч эхийг даатгуулсан хэлбэрээс нь хамаарч жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг ялгаатай тогтоодог байсныг өөрчилж 2020 оноос албан журмын даатгуулагчийн нэгэн адилаар 100 хувиар тооцуулан 4 сарын хугацаанд авах боломжтой болсон.

➤ **Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал**

Хөдөлмөрийн холбогдох хуулиудад хөдөлмөрийн харилцаанд аливаа хэлбэрээр ялгаварлах, хязгаарлах, давуу байдал тогтоохыг хориглосон. Түүнчлэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд иргэн сайн дурын үндсэн дээр хөдөлмөр эрхлэлтэд хамрагдахаар заасан байдаг. Иймд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагаанд хүнийг эрэгтэй, эмэгтэйгээс үл хамааран эрх тэгш, нээлттэй хамруулах зарчмыг баримталж байна.

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн статистик үзүүлэлтээс харахад<sup>3</sup> 2018 оны байдлаар 15 ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхитэй хүн ам нь нийт хүн амын 41.9 хувийг эзэлж байна. Үүний 53.7 хувь нь эрэгтэй, 46.3 хувь нь эмэгтэйчүүд байна.

Ажиллах хүчний оролцооны түвшин 2018 онд улсын хэмжээнд 61.0 хувь байгаа бөгөөд энэ нь хот суурин газарт 53.4 хувь, харин хөдөөд 66.7 хувьтай байна. Эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин эмэгтэйчүүдийнхээс 13.9 пунктын зөрүүтэй байгаа нь эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт эмэгтэйчүүдийнхээс илүү байгааг харуулж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, төрөл, хэлбэрийг “халамжаас хөдөлмөр эрхлэлт рүү” зарчмын хүрээнд өөрчилж, үйлчилгээний тогтвортой, хүртээмжтэй байдлыг

---

<sup>3</sup> www.1212.mn

бүрдүүлэх зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч мэргэжилтэн авах тухай хуулийг шинэчлэн боловсруулав. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, залуучууд, малчид зэрэг зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 6 дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Хөтөлбөрт хамрагдсан нийт иргэдийн 50.4 хувь нь эмэгтэйчүүд байна.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хот, аймаг, сумаас хөдөөд шилжин суурьшиж, мал маллах хүсэлтэй өрхийг тогтвортой ажлын байраар хангаж, тогтмол орлоготой болгох зорилгоор гэрээт малчин өрхийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлж байна. 2019 оны байдлаар уг арга хэмжээнд 259 өрхийн 425 иргэн хамрагдаж, 206,202.3 мянган төгрөгийг зарцууллаа.

### **Ахмад настны эрхийн чиглэлээр**

Монгол Улсын нийт хүн амын 8.9 хувийг ахмад настан эзэлж байна. Дундаж наслалт эрэгтэйчүүд (66.1 жил), эмэгтэйчүүд (75.8 жил)–ийн хооронд 9.7 жилийн зөрүүтэй байгаа ба эрэгтэйчүүдийн дундаж наслалт удаан нэмэгдэж байна. Нийт хүн амын тоо сүүлийн 10 жилд 16.1 хувиар өссөн байхад ахмад настны тоо 22 хувь буюу илүү хурдацтайгаар өсч, 2030 онд 12.9 хувь, 2045 онд 16.3 хувь хүртэл өсөх төлөвтэй байна.

Засгийн газраас 2016, 2018, 2019 онуудад үе шаттай нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 39,4 хувь, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 38,9 хувь, дундаж тэтгэврийг 30,7 хувь тус тус нэмэгдүүлсэн байна.

Ахмад настнуудад үзүүлэх нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах, эмзэг байдалд өртөхөөс сэргийлэх үүднээс нийгмийн халамжийн дэмжлэг туслалцааг нэмэгдүүлж 2016 онтой харьцуулахад нийгмийн халамжийн тэтгэвэр 34,3 хувь, асаргааны тэтгэмж мөн хувиар тус тус өссөн байна.

### **Дөрөв. Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог өсгөн**

**нэмэгдүүлэх чиглэлээр /Зөвлөмж – 108.44, 108.47, 108.48,**

**108.139, 108.140, 108.141, 108.142/:**

Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолоор “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр” (2017–2021 он)–ийг нийт 1,0 тэрбум төгрөгийн төсөвтэйгээр баталснаас гадна Засгийн газрын 2018 оны 111, 285 дугаар тогтоолоор Жендерийн үндэсний хорооны ажлын албыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны бүтцээс гаргаж, Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд салбар дундын уялдааг хангасан, бие даасан бүтэц, төсөвтэйгээр ажиллуулж байна.

“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”–т заасан эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн жендэрийн боловсролыг бүх нийтэд олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг 500 гаруй иргэнд нийт 16 удаагийн сургалт–семинараар хүргэлээ. МУИС–ийн Сэтгүүлзүйн болон нийгмийн ажилтны хичээлийн хөтөлбөрт жендэрийн асуудлыг тусгав.

“Ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгох талаар үндэсний хэмжээнд баримтлах бодлого”–ыг боловсруулж, Хөдөлмөр нийгмийн зөвшлийн 3 талт үндэсний

хорооны 2020 оны ээлжит хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байна. Мөн УИХ-аас Зөрчлийн тухай хуульд ажлын байрны бэлгийн дарамтын талаарх зохицуулалтыг байгууллага, аж ахуй нэгж хөдөлмөрийн дотоод журамдаа тусгаагүй бол торгууль оногдуулах нэмэлт өөрчлөлтийг тусгаж баталлаа.

Ажил эрхэлдэг нийт эмэгтэйчүүдийн дунд удирдах албан тушаал эрхэлдэг эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2018 оны байдлаар 35,9 хувьтай байна. Харин төрийн албанд нийт 193,557 албан хаагч ажиллаж байгаагаас 60.4% эмэгтэйчүүд байна.

Төрийн албаны тухай шинэ хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан төрийн албан хаагчийн мэргэшүүлэх багц сургалтын агуулгад жендэр, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт, ажлын байрны дарамт, жендэрийн статистик, хяналт-шинжилгээ, үнэлгээ сэдвийг тусгалаа. Мөн Жендэрийн үндэсний хорооны дэргэд Сургалт, судалгааны танхим байгуулж “Жендэр ба бодлого төлөвлөлт” сургагч багшийн гарын авлага, модуль боловсруулж, тус модулиар Жендэрийн үндэсний сургагч багшийг 2018 оноос эхлэн шат дараатайгаар бэлтгэж байна. Үндэсний хэмжээнд нийт 4 удаагийн сургалтаар 104 сургагч багш бэлтгэгдээд байна. Төрийн албаны Удирдах ажилтанд зориулсан жендэрийн цахим сургалтын модулийг боловсруулж, тус цахим сургалтад төрийн албаны 600 гаруй удирдах албан тушаалтныг хамруулж, 300 гаруй албан тушаалтанд гэрчилгээг олгов.

Төрийн бодлогын хэрэгжилтийг баталгаажуулах үүднээс жендэрийн тэгш байдлыг хангах бодлого, хөтөлбөрийг салбар, орон нутгийн түвшинд нутагшуулах ажлыг 2014 оноос эхлүүлсэн. Өнөөгийн байдлаар Засгийн газрын 8 яам жендэрийн эрх тэгш байдлын салбарын бодлогоо батлав. Мөн 21 аймгаас 18 аймаг жендэрийн дэд хөтөлбөрийг батлуулж, хэрэгжүүлж байна. Жендэрийн статистикийн үзүүлэлтийн хүрээ болон тооцох аргачлалыг Үндэсний статистикийн хороотой хамтран шинэчлэн баталлаа.

“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-т Улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүлсэн. УИХ-ын 2016 оны сонгуульд нийт 13 эмэгтэй гишүүн сонгогдсон нь өмнөх жилүүдээс хамгийн их суудал авсан буюу 17%-ийн эзэлж байна. 2019 оны байдлаар Засгийн газрын яамд, агентлаг, нийслэл, аймаг, дүүргийн газар, хэлтсийн дарга нарын 40 хүртэлх хувь нь эмэгтэйчүүд томилогдон ажиллаж байна. Цаашид Төрийн албаны тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд энэ тоо буурахгүйгээр нэмэгдэх хандлагатай байна.

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 30 дугаар зүйлд нийт нэр дэвшигчдийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байхаар хуульчилсан бөгөөд Хүний эрхийн Комиссын тухай шинэ хуульд нийт 5 гишүүний 40 хувь нь аль нэг хүйсийн гишүүн байхаар тусгасан.

**Тав. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр** /Зөвлөмж – 108.84, 108.86, 108.87, 108.88, 108.90, 108.91, 108.92, 108.94, 108.95, 108.96, 108.98, 108.99, 108.100, 108.101, 108.103, 108.105/ :

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/27 тоот тушаалаар Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үүрэг бүхий Дэд зөвлөлийг байгуулсан ба бүрэлдэхүүнд нь хуулиар чиг үүрэг хүлээсэн бүх салбарын яам, агентлаг, төрийн бус байгууллагуудын төлөөлөл багтдаг.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэх, хуулиар үүрэг хүлээсэн салбаруудын хамтын ажиллагаа, уялдаа холбоо, салбар дундын зохицуулалтыг үндэсний, салбар болон орон нутгийн түвшинд хангах зорилгоор “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд олон талт хамтын ажиллагаа” Үндэсний чуулганыг 2017 оноос хойш жил бүрийн 4 дүгээр сард зохион байгуулдаг болсон. Чуулганд яамд, 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн зэрэг оролцогч бүх талуудын төлөөлөл болох нийт 200 хүн оролцож, хуулийн хэрэгжилт, үр дүн, хүндрэл бэрхшээлийн шийдлийг хэлэлцдэг.

Монгол дахь жендэрт суурилсан хүчирхийлэл гэр бүлийн хүчирхийллийн тархалтын судалгааг 2017 онд улсын хэмжээнд хийсэн бөгөөд уг судалгаагаар эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэж буй хүчирхийллийн түвшинг тогтоосон ба судалгааны дүнд үндэслэн Гэр бүлийн хүчирхийлэл их гардаг, хохирогч хамгаалал шаардлагатай Баян-Өлгий, Дархан-Уул, Дорнод, Өвөрхангай, Өмнөговь, Хөвсгөл, Хэнтий аймаг, Баянзүрх, Хан-Уул дүүрэгт хохирогчдод тусламж, үйлчилгээ үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээний төвийг шинээр байгуулсан. Уг ажлыг зохион байгуулахад орон нутгаас 623 сая төгрөг, олон улсын байгууллагаас 764,5 сая төгрөг тус тус зарцуулсан.

Байр, төвийн тоо, үйлчлүүлсэн хүний тоо:

	2015 онд	2016 онд	2017 онд	2018 онд	2019 онд
Нэг цэгийн үйлчилгээний төв	7	8	10	11	15
Түр хамгаалах байр	2	3	6	9	14
Үйлчлүүлсэн хүний тоо				1739	2417

Түр хамгаалах байрны 1 хүүхдэд ноогдох өдрийн зардлыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын А/80 тоот тушаалаар батлагдсан зардлаар<sup>4</sup> тооцож, төрийн бус байгууллагад өгч байна.

Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тэмцэхэд хууль зүйн салбарын чадавх, уялдаа холбоог бэхжүүлэх зорилгоор сургалтын гарын авлагыг боловсруулан, нийслэл, 21 аймгийн цагдаа, прокурор, шүүгч, өмгөөлөгч, нийгмийн ажилтан, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Салбар зөвлөлийн гишүүд зэрэг нийт 1000 хүнд сургалтыг зохион байгуулав.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх 21 аймаг, 9 дүүргийн Хамтарсан баг /2017 онд 609 хамтарсан багийн 4634 гишүүд, 2019 онд 676 хамтарсан багийн 4714 гишүүд/-ийн бүх гишүүдийг сургалтад хамруулж, ур чадварыг нь нэмэгдүүлсэн.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын гарын авлага, материалыг боловсруулж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон цагдаагийн байгууллагын сэтгэл зүйч, нийгмийн ажилтнуудад сургалтыг зохион байгуулж эхлээд байна.

НҮБ-ын Ерөнхий Ассемблейн шийдвэрээр 1999 оноос эхлэн жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны өдрийг охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох олон

<sup>4</sup> 19150 төгрөг



улсын “Цагаан туузтаны өдөр” болгон зарласныг 2017 онд “Хайрла, хамгаал”, 2018 онд “Эерэг болГоё”, 2019 онд “ойлГОЁ–ХҮНдэлье” уриан дор улсын хэмжээний аян зохион байгуулж, хүчирхийллийг үл тэвчих нийгмийн ухамсар, иргэдийн мэдээллэх үүрэг, хүчирхийллийн хор уршгийг таниулсан сурталчилгааг уламжлалт хэвлэл мэдээллийн суваг болон сошиал мэдиагаар давтагдсан тоогоор 7,1 сая иргэд, олон нийтэд хүргэсэн. Үүний үр дүнд гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх Цагдаагийн байгууллагад ирэх дуудлага, мэдээллийн тоо өссөн дүнтэй байна.

Цагдаагийн Мэдээллийн технологи, холбооны төвийн гэмт хэрэг, зөрчлийн дуудлага, мэдээлэл хүлээн авдаг ECS, ECS mobile программуудад нэмэлт хөгжүүлэлт хийж eGBV гэсэн тусдаа программыг нэвтрүүлсэн. Уг eGBV гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, үйлчдэгч нарын мэдээллийг зөвхөн Цагдаагийн байгууллагын алба хаагчаас гадна нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр, хамтарсан багууд мэдээллээр баяжуулж эхэлсэн нь хохирогчдод үзүүлэх үйлчилгээний үр нөлөө, оновчтой байдлыг зохистой төлөвлөж, хүргэхэд ач холбогдолтой болсон.

Шүүхээс Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэргээр 2017 онд 59, 2018 онд 146, 2019 оны 3 дугаар улирлын байдлаар 172 хэргийг хянан шийдвэрлэсэн байна.

**Зургаа. Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр /Зөвлөмж –108.109, 108.110, 108.111, 108.112, 108.114, 108.115, 108.151/:**

2017 онд Ерөнхий сайдын захирамжаар Хүүхдийн төлөө зөвлөлийг шинэчлэн байгуулж, жил бүр салбар дундын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна.

Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр болон хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус батлан, хэрэгжүүлж байна.

Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудад заасан үйлчилгээний дүрэм, журам стандартуудыг батлан хэрэгжүүлж байна. Тухайлбал: Хүүхэд хамгааллын тухай хуулиар хүүхдийг гэр бүл, боловсрол, эрүүл мэнд, цахим орчин, олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээ зэрэг 5 орчинд хамгаалахаар заасны дагуу Хүүхдийн хөгжил, хамгааллын стандартчиллын техникийн хороо байгуулагдан, хүүхдийн зуслан, ЕБС–ийн дотуур байрын орчин, үйлчилгээ, хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, Хүүхдийн тоглоомын талбайн орчинд тавигдах шаардлага стандартуудыг тус тус батлан мөрдөж байна.

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны журмын дагуу аймаг, дүүрэгт хууль зөрчсөн, гэмт хэргийн гэрч, хохирогч болсон хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх чиг үүрэгтэй салбар дундын “Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо” 2017 онд байгуулагдан ажиллаж байна. Уг хорооны үйл ажиллагааг тогтмолжуулж, мэргэжил арга зүйн зөвлөмж, чиглэл өгч ажилласны үр дүнд хороогоор үйлчлүүлсэн хүүхдийн тоо 2017 онд 618, 2018 онд 902 болж өссөн үзүүлэлттэй байна. Тус хороодын гишүүдийг чадавхжуулах сургалтын гарын авлага номыг боловсруулан, 2019 онд хорооны төрийн албан хаагч 270 гишүүдийг сургалтад хамруулаад байна.

Түүнчлэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/476 дугаар тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлого”–ыг батлан хэрэгжүүлж байна. Бодлогыг хэрэгжүүлэх зөвлөмж гарын

авлагыг боловсруулж, ерөнхий боловсролын сургуулийн захирал, нийгмийн ажилтныг чадавхжуулах Үндэсний сургалтыг 21 аймаг, Улаанбаатар хотод зохион байгуулснаас гадна холбогдох нөлөөллийн ажлыг сургууль, цэцэрлэгийн багш, сурган хүмүүжүүлэгч, эцэг эхчүүдэд шат дараатай зохион байгуулж байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын 138, 182 дугаар конвенцийн заалтад нийцүүлэн насанд хүрээгүй ажилтны хөдөлмөрийн насыг суурь боловсрол эзэмших насанд уялдуулж, хөнгөн ажил эрхэлж болох насыг 13–15 нас болгож, урлаг, спортын үзүүлбэр, зар сурталчилгаанд хүүхэд оролцуулахаар бол хүүхдийн эрхийн байцаагчаас тухай бүр зөвшөөрөл авах зохицуулалтыг орууллаа.

**Долоо. Хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр** /Зөвлөмж – 108.116, 108.117, 108.119, 108.120, 108.121, 108.122, 108.123/ :

“Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх” үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолоор баталсан ба энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Дэд зөвлөлийг 2017 онд байгуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны Б/284 дүгээр тушаалаар Эрүүгийн цагдаагийн албанд бүтцийн өөрчлөлт хийж хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тасгийг шинээр байгуулсан.

Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс 2018 онд 709 сая төгрөг, 2019 онд 506 сая төгрөгийг тус тус төсөвлөсөн. Уг төсвөөс зөвлөх үйлчилгээ үзүүлсэн төрийн бус байгууллагад 2017 онд 16,9 сая төгрөг, 2018 онд 95 сая төгрөг, 2019 онд 115,6 сая төгрөгийн санхүүжилт тус тус олгосон.

*Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, Хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын алба хаагчдын хүн худалдаалах гэмт хэргийн талаарх ойлголт, мэдлэг, туршлага, чадавхийг үнэлэх судалгаа хийхийн зэрэгцээ цагдаа болон прокурор, хил хамгаалах, гадаадын иргэн харьяатын байгууллагын алба хаагч, шүүгч, өмгөөлөгч, нийгмийн ажилтан, эрүүл мэндийн ажилтан нарыг мэргэшүүлэх, мэргэжил, ур чадварыг нэмэгдүүлэх сургалтыг улсын хэмжээнд тасралтгүй зохион байгуулж байна.*

Цахим орчин дахь зохистой хэрэглээг бий болгох, хүүхдийг цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг, түүний дотор хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “UNFRIEND” үндэсний хэмжээний аянг зохион байгуулж урьдчилан сэргийлэх агуулга бүхий 55 постер, 15 видео сурталчилгаа, нэвтрүүлэг, 1 дуу бүтээж 31 телевиз, олон нийтийн цахим сүлжээгээр түгээсэн нь давхардсан тоогоор 6.101.000 хүнд хүргэсэн.

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газрууд тухайн орон нутгийн 18 телевиз болон 26 радио, тухайн аймгийн “facebook” цахим хуудсанд хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг мэдээ, мэдээлэл, шторкуудыг тогтмол байрлуулж байна.

Нөлөөллийн ажлын үр дүнд хүн худалдаалах гэмт хэргийн талаарх иргэдийн ойлголт,

мэдлэг нэмэгдэж өөрсдийгөө энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн эсэхэд үнэлгээ хийх чадвар нэмэгдсэн, нөгөө талаас төрийн албан хаагч, үйлчилгээ үзүүлэгч нарыг гадаад болон дотооддоо илрүүлэх ур чадвар нэмэгдэж, хохирогчид үзүүлэх үйлчилгээг сайжруулсан. Эдгээрийн үр дүнд 2018 онд нийт 19 иргэн, 2019 онд 7 иргэнийг тус тус гадаад улсаас эх оронд нь аюулгүй буцаан авчрах ажлыг олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр зохион байгууллаа.

Хүн худалдаалах гэмт хэргийн талаар Цагдаагийн сургуулийн мэргэжлийн хичээлийн агуулгад 2–6 цагийн багтаамжтай оруулж, сургалтыг зохион байгуулж байна.

Тусгай арга хэмжээний үеэр олон нийтийн сүлжээн дэх садар самуун сурталчилсан болон хууль бус агуулга бүхий контент агуулсан групп, пэйж хуудсуудын мэдээллийг хүлээн авах “Хар жагсаалт” группыг үүсгэн 19,300 гишүүнийг элсүүлэн ажилласны зэрэгцээ хууль бус үйл ажиллагаа явуулсан 32 нийгмийн сүлжээний хуудас, группыг илрүүлж, Фэйсбүүк–д REPORT явуулж устгах арга хэмжээг авч эхэлсэн.

Хилээр нэвтэрч буй иргэдэд хүн худалдаалах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэг, мэдээллийн агуулгатай паспортын хавчуурга бэлтгэн хэвлүүлж, тогтмол тарааж байна.

#### **Найм. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангах чиглэлээр**

*/Зөвлөмж – 108.131, 108.132, 108.133, 108.134, 108.135, 108.136, 108.137, 108.138/:*

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйл дотоодын хуультай нийцэж байгаа эсэхэд судалгаа хийсэн бөгөөд уг судалгаанаас зарим хуулиудын зүйл заалт хоорондоо нийцэхгүй байна гэсэн дүгнэлт гарсан. Уг дүгнэлтийг үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/233 дугаар тушаалаар Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчлэн боловсруулах Ажлын хэсгийг байгуулсан бөгөөд Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хэвлэн мэдээлэх эрх чөлөөтэй холбоотой иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл орсон.

Эрүүгийн хуульд нэр төр гутаах үйлдлийг гэмт хэрэгт тооцоогүй харин Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах үйлдлийг гэмт хэрэгт тооцон хуульчилсан.

#### **Ес. Ялгаварлан гадуурхах бүх хэлбэр, тэр дундаа ЛГБТ хүмүүсийг**

**ялгаварлан гадуурхахтай тэмцэх чиглэлээр** /Зөвлөмж – 108.19, 108.20, 108.21, 108.41, 108.42, 108.53, 108.57/ :

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс “Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж дахь ялгаварлан гадуурхахын эсрэг зохицуулалтын хэрэгжилт: бэлгийн цөөнхөд холбогдох зохицуулалт” сэдэвт судалгааг хийсэн бөгөөд уг судалгаанаас ялгаварлан гадуурхахын эсрэг бие даасан хууль батлахаас илүүтэйгээр салбар тус бүрт, холбогдох хууль тогтоомжид шаардлагатай зохицуулалтыг тусгах байдлаар шийдвэрлэх нь хэрэгжих боломжийн хувьд үр нөлөөтэй гэсэн дүгнэлтийг гаргасан. Цаашид энэ чиглэлд анхаарал хандуулахаар ажиллаж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамаас жил бүр Залуучуудын хөгжлийг дэмжих

сарын аяныг зохион байгуулдаг бөгөөд 2019 оны аяны хүрээнд бэлгийн болон хүйсийн чиг баримжаа өөр хүмүүсийн нийгэмд ялгаатай байдлыг хүндлэхэд залуучууд, иргэд, олон нийтийг уриалах, бэлгийн цөөнхийн талаарх үнэн бодит мэдээллийг түгээх, тэдгээрийн эсрэг хүний эрхийн зөрчлийг зогсоох асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах зорилготой “Тэгш эрх, бахархлын өдрүүд” арга хэмжээ зохион байгууллаа.

Мөн Эрүүл мэндийн яамнаас “ХДХВ, ДОХ–оос үүдэлтэй ялгаварлан гадуурхалтыг зогсооё”, “Өөрчлөлтийг та, бид хийж чадна”, “Бид нэг тэнгэртэй” нэрийн дор нөлөөллийн арга хэмжээнүүдийг бэлгийн чиг баримжаа өөр хүмүүс болон ХДХВ–ийн халдвартай амьдарч байгаа хүмүүсийн талаарх эерэг ойлголт мэдээллийг түгээх зорилгоор зохион байгуулав.

“Эрсдэлт бүлгийн хүн амд тусламж үйлчилгээ үзүүлэгчдийн хандлагыг өөрчлөх, нөлөөлөх чадавхжуулах” сургалтаар резидент эмч нарыг бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл, түгээмэл тохиолдох БЗДХ, ХДХВ, ДОХ өвчний оношлогоо эмчилгээ, урьдчилан сэргийлэлтийн талаарх ойлголтыг төлөвшүүлэхээр явуулж байна.

**Арав. Олон улсын гэрээнд нэгдэн орох, дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх, хүний эрхийн гэрээний хэрэглээг сайжруулах, сургалт зохион байгуулах чиглэлээр / Зөвлөмж – 108.17, 108.18, 108.49, 108.26, 108.36/:**

“Монгол Улсын олон улсын гэрээний тухай хуулийг 2016 шинэчилж баталсан бөгөөд олон улсын гэрээг соёрхон батлахдаа дотоодын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг хамтад нь боловсруулж батлуулж байхаар хуульчилсан. Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийг шинэчлэн баталсан ба уг хуулиар шинээр боловсруулж байгаа хуулиудад хүний эрхэд нөлөөлөх үр нөлөөг урьдчилан тооцдог болгосон.

Гэхдээ олон улсын гэрээний тухай ойлголт мэдлэгийг бүх түвшинд гүнзгийрүүлэх, түүнийг хэрэгжүүлэх ажлыг улс орны болоод салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөртэй уялдуулах, мөн гэрээний хэрэгжилт, түүнийг тайлагнах ажлыг нэгдсэн бодлого, механизмаар хангах хэрэгцээ шаардлага байсаар байна. Иймд Үндэсний тайлагнах, хэрэгжүүлэх механизмыг (NRMF) боловсронгуй болгох, үндэсний чадавхийг бэхжүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах, үндэсний зөвлөмжийн хэрэгжилтийг хянах мэдээллийн сан (NRTD) НҮБ–ын ХЭДКА–тай хамтран ажиллаж байна.

Шинэ Эрүүгийн хуулийн 29 дүгээр бүлэг буюу Хүн төрөлхтөний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг гэсэн бүлэгт түрэмгий дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх, төрлөөр устгах зэрэг Ромын дүрэмд хамаарах зохицуулалтыг тусгасан. Мөн УИХ–аас Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрмийн “Түрэмгийллийн гэмт хэргийн тухай болон Дайны гэмт хэргийн тухай 8 дугаар зүйлийн нэмэлт, өөрчлөлт” болон Олон улсын эрүүгийн шүүхийн дархан эрх ямба, дархан эрхийн тухай хэлэлцээрийг соёрхон батлах хуулийн төслүүдийг хэлэлцэж байна.

Монгол Улс НҮБ–н Аюулгүйн зөвлөлийн 1325 дугаар тогтоолыг судалж, үндэсний хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд цаашид хэрэгжүүлэх үндэсний төлөвлөгөөг батлан хамгаалах, аюулгүй байдлын салбар дахь жендэрийн асуудлыг судлах, сайжруулахад чиглүүлэх, чингэхдээ батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй байгууллагуудыг хамруулахаар ажиллаж байна.

**Арван хоёр. Бусад /Зөвлөмж – 108.144, 108.145, 108.162, 108.160, 108.52, 108.125, 108.129/**

Гадаад харилцааны сайдын тушаалаар НҮБ–ын Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмыг хэрэгжүүлэх үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах Ажлын хэсгийг байгуулж, төлөвлөгөө боловруулах үйл явцыг 2019 оны 5 дугаар сард албан ёсоор эхлүүлэв. Энэ ажилд НҮБ–ын Хүний эрхийн зөвлөлийн Бизнес ба хүний эрхийн асуудал хариуцсан Ажлын хэсэг мөн ХЭДКА оролцсон. Үндэсний төлөвлөгөө боловсруулахад техник, арга зүйн зөвлөлгөө, туршлага авах зорилгоор НҮБ–ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ–ын ХЭДКА мөн Европын холбоотой хамтран ажиллаж байна.

ДЭМБ, БНСУ–ын Олон улсын эрүүл мэндийн сан, Солонгосын иргэдийн сантай хамтран “Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд мобайл технологийн хэрэглээг нэвтрүүлэх, өргөжүүлэх” төслийг 21 аймаг 9 дүүргийн 114 өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд хэрэгжүүлж, зөөврийн зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, зөөврийн ЭХО, цусны даралт хэмжигч аппарат, сахар, холестерол хэмжигч, 4 төрлийн хурдавчилсан оношлуур, шинжилгээ авахад хэрэглэгдэх эмнэлгийн хэрэгсэл зэрэг тоног төхөөрөмжөөр хангаж, эмч, эрүүл мэндийн нийгмийн ажилтан, сувилагч, лаборантуудыг сургаж бэлтгэсэн. Уг үйл ажиллагааг дэмжиж Төв, Булган, Дундговь, Хэнтий аймгийн Засаг дарга нар өөрийн санхүүжилтээр мобайл технологийг өргөжүүлж, аймгийн 50 анхан шатны эрүүл мэндийн байгууллагад төслийг нэвтрүүлж, эмч, мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалтад 90 хүнийг хамруулан зохион байгууллаа.

Монгол Улс нь НҮБ–ын Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай Конвенцид нэгдэж ороогүй хэдий ч Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон нэгдэн орсон хүний эрхийн бусад конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллаж байна. НҮБ–ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн комиссариатын газраас шийдвэрлэгдэж хариу иртэл гуравдагч орон руу дүрвэх зорилгоор ирж байгаа болон тус улсад оршин сууж байгаа дүрвэх хүсэлт гаргасан гадаадын иргэнд Монгол Улсад хууль ёсоор оршин суух зөвшөөрлийг Гадаадын иргэн, харьяатын газраас холбогдох журмын дагуу олгож байна.

Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”–г батлан хэрэгжүүлж байна. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, давхардсан тоогоор 4030 нийтийн албан тушаалтан, иргэнийг хамруулаад байна. Шударга байдлыг хүүхэд багачуудад тэдгээрийн нас сэтгэхүйд зориулан жүжигчилсэн хэлбэрээр таниулах, мөн шударга ёсыг эрхэмлэх, төлөвшүүлэх, авлигын хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор радиогийн богино хэмжээний нэвтрүүлэг СПОТ бэлтгэж, дүрсжүүлэн олон нийтийн хүртээл болгох зэргээр олон арга хэмжээг авч байна.

Мөрдөн шалгах ажлын хувьд 2018 оны эхний 9 сарын байдлаар хугацаанд хуульд заасан харьяаллын дагуу 871 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсныг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, мөрдөн шалгасан хэрэг 3 дахин, шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн хэрэг 2.3 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх Хууль зүйн туслалцааны төв нь улсын хэмжээнд 21 аймаг, нийслэлийн 8 дүүрэг, хүн ам ихээр суурьшсан 2 сум, нийт 31 салбарт 52 улсын өмгөөлөгч, 7 өмгөөлөгчийн туслах ажиллаж байна. Тэдгээрийг хуульчийн багц сургалтад хамруулж байна.

2016–2019 онд шүүхээр болон шүүхийн өмнөх шатанд шийдвэрлүүлсэн нийт 6019 хэргийн 6689 холбогдогчийн 846 нь насанд хүрээгүй хүүхэд, 1253 нь бичиг үсэг тайлагдаагүй, 309 нь хөгжлийн бэрхшээлтэй, оршин суух тодорхой хаяггүй Монгол Улсын иргэн 14, гадаадын иргэн 13 байна.

Хууль зүйн туслалцааны тухай хуулийг шинэчлэн боловсруулж байгаа бөгөөд уг төсөлд хууль зүйн туслалцаа авах субъектын хүрээг хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн арван найман насанд хүрээгүй хохирогч, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогч, төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч гэх зэргээр өргөжүүлэхээр тусгаад байна.

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай Засгийн газар болон хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шаарлагатай 7 журмыг баталснаар гэр хороололд оршин суугч иргэдийн эзэмшил, өмчлөлийн газартай холбогдсон эрхийн зөрчил дахин давтагдахгүй байх нөхцөлийг бүрдүүлэв. Мөн гэр хорооллын иргэдэд дээрх хууль, журмыг сурталчлах, мэдээллээр хангах зорилгоор Барилга хот байгуулалтын яам, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Японы ЖАЙКА олон улсын байгууллагатай хамтран “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны сургагч багшийг бэлтгээд байна.

### **В.ХЭРЭГЖИХ БОЛОМЖГҮЙ ЗӨВЛӨМЖ /108.69, 108.70/**

Цаазаар авахуулсан хүмүүсийн гэр бүлийг нууцаас хассан холбогдох мэдээллээр хангах, цаазаар авах ялын гүйцэтгэлийг улсын нууцын мэдээллээс хасах асуудлаар холбогдох байгууллагууд судалж үзээд, эдгээрийг хэрэгжүүлэх боломжгүй байна гэсэн дүгнэлтэд хүрлээ.

**Г. ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ:** Монгол Улс нь зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх төлөвлөгөөндөө хариуцан хэрэгжүүлэх байгууллагуудыг тодорхой заагаагүйгээс салбар дундын арга хэмжээнүүдийн хэрэгжилтэд хүндрэл гарсан бөгөөд мөн улс орны эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотой төсвийн хуваарилалтын хангалттай бус байдал нь хэрэгжилтэд нөлөөлсөн.

**9.8 НҮБ–ЫН ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨВЛӨЛИЙН ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ  
БАЙДЛЫГ ХЯНАН ХЭЛЭЛЦЭХ ЭЭЛЖИТ НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ (UPR)–ИЙН  
АЖЛЫН ХЭСГИЙН 36 ДУГААР ЧУУЛГАНААР МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ  
ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТАЛААРХ ҮНДЭСНИЙ ГУРАВДУГААР ИЛТГЭЛИЙГ  
ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ҮЕЭР БУСАД УЛСААС ӨГСӨН ЗӨВЛӨМЖ**

1. Үндэсний хууль тогтоомжийг Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад нийцүүлэх, эрх зүйн шинэтгэл явуулахдаа иргэний нийгмийн оролцоог хангах (Украин);
2. Цөмийн зэвсгийг хориглох тухай гэрээнд гарын үсэг зурж, нэгдэн орох (Гондурас);
3. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколд заасны дагуу эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизм бий болгох (Казахстан), Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколд заасны дагуу эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үр дүнтэй механизмыг хойшлуулшгүйгээр бий болгох (Украин);
4. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколд заасны дагуу эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизм бий болгох үйл явцыг хурдасгах, эрүү шүүлт, тэр дундаа эрх чөлөөг нь хассан хүнийг эрүүдэн шүүсэнтэй холбоотой гомдлыг шалган шийдвэрлэх бие даасан, үр дүнтэй процедур бий болгох (Мексик);
5. UPR–ын хоёр дахь илтгэлийн мөрөөр байгуулсан орон тооны бус зөвлөлийг хүний эрхийн бүх зөвлөмжийг хэрэгжүүлэх, тайлагнах, мөрөөр ажиллах асуудал хариуцсан байнгын ажиллагаатай яам хоорондын механизм болгож шинэчлэн байгуулах (Португал);
6. Хүний эрхийн олон улсын гэрээний байгууллага, механизмаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх, тайлагнах, мөрөөр ажиллах асуудал эрхэлсэн байнгын ажиллагаатай засгийн газрын бүтэц /NMIRF/ бий болгох (Бахам);
7. Хүний эрхийн олон улсын байгууллага, тэр дундаа Хүний эрхийн зөвлөлийн Тусгай процедур, гэрээний байгууллагуудтай үргэлжлүүлэн хамтран ажиллах (Пакистан);
8. НҮБ–ын Гэрээний хороодын сонгуульд нэр дэвшүүлэхдээ мерит зарчимд суурилсан нээлттэй сонгон шалгаруулалт явуулдаг болох (ИБУИНХУ);
9. Үндэсний хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын стандартад нийцүүлэх ажлыг үргэлжүүлэх (Венесуэл);
10. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг үргэлжүүлэн хэрэгжүүлэх (Израиль);
11. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хариуцаж байгаа албан хаагчдыг сургалтад хамруулах, зохих нөөц хуваарилах замаар хуулийн үр

- нөлөөг нэмэгдүүлэхэд анхаарах (Перу);
12. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх санхүүжилтийг нэмэгдүүлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, мэдээлэх чиг үүрэгтэй салбаруудын хамтын ажиллагааг өргөжүүлэх (Австрали);
  13. Хүний эрхийг хамгаалагчдын хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээрх үйл ажиллагаагаа чөлөөтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүднээс тэднийг хүлээн зөвшөөрч, хамгаалахад чиглэсэн хууль тогтоомж баталж хэрэгжүүлэх (Ирланд);
  14. Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах тухай хуулийн төслийг аль болох хурдан эцэслэн батлах (Швейцар);
  15. Үндэсний болон салбарын үндсэн бодлого, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх замаар олон улсын үүрэг амлалтаа биелүүлэх чиглэлээр хүчин чармайлтаа үргэлжлүүлэх (БНАСАУ);
  16. Эмзэг бүлгийн хүмүүсийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, тэдний хууль ёсны эрхийг хангах талаар үргэлжлүүлэн анхаарч ажиллах (Кувейт);
  17. Хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ахмад настан зэрэг эмзэг бүлгийн иргэдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагаагаа сайжруулах чиглэлээр хүчин чармайлтаа үргэлжлүүлэх (Лаос);
  18. Эмзэг бүлгийн, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлээр хүчин чармайлтаа үргэлжлүүлэх (Ливан);
  19. Хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, өндөр настан зэрэг нийгмийн эмзэг бүлгийн гишүүдийн эрхийг хууль тогтоомжоор болон практикт үргэлжлүүлэн хамгаалах (ОХУ);
  20. Ард иргэд, тэр дундаа нэн эмзэг бүлгийн иргэдийн амьдралын чанарыг сайжруулахын тулд халамж, нийгмийн хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн бэхжүүлэх (Вьетнам);
  21. Хүний эрхийн үндэсний комиссын эрх хэмжээ, түүний дотор үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг шинэ хууль тогтоомжийн дагуу улам бүр бэхжүүлэх (Гүрж);
  22. Парисын зарчмын дагуу Хүний эрхийн үндэсний комиссыг бэхжүүлэхэд анхаарах (Энэтхэг);
  23. Парисын зарчимд бүрэн нийцүүлэн Хүний эрхийн үндэсний комисст зохих хүний болон санхүүгийн нөөцийг хуваарилах (Казахстан);
  24. Хүний эрхийн салбарт хүртээмжтэй, цогц хандлагыг бий болгох зорилгоор бүс нутаг дахь хүний эрхийн үндэсний байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх (Армени);
  25. Хүний эрхийн боловсролыг төрийн бодлогын бүрэлдэхүүн хэсэг болгон нэгтгэх арга хэмжээг үргэлжлүүлэн авах (Пакистан);
  26. Шүүхэд болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэх үр дүнтэй хууль, эрх зүйн эх сурвалж бий болгох үүднээс төр болон хувийн хэвшлийн салбар дахь шууд ба шууд бус ялгаварлан гадуурхалттай тэмцэх цогц хууль батлах асуудлыг авч үзэх (Чили);
  27. Ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэртэй тэмцэх талаарх хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэх арга хэмжээг бэхжүүлэх (Аргентин);



28. Шууд ба шууд бус ялгаварлан гадуурхах асуудлыг зохицуулж, ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэр, тэр дундаа хүйсийн болон бэлгийн чиг баримжаагаар нь ялгаварлан гадуурхахыг хориглосон цогц хууль батлах (Исланд);
29. ЛГБТИ хүмүүсийн эсрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хүлээцтэй байдлыг хөхиүлэн дэмжих зорилгоор олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх кампанит ажлыг эхлүүлэх (Исланд);
30. Хүмүүсийг бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаа, интерсекс байдал, хүйсийн илэрхийлэл зэргээр ялгаварлан гадуурхах, дарамт шахалт үзүүлэхээс хамгаалах хуулийн заалтыг улам боловсронгуй болгох, хэрэгжүүлэх (Израиль);
31. Монгол Улсын Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан трансжэндэр болон интерсекс хүмүүс хүйсээ хууль ёсоор бүртгүүлэхэд эмнэлгийн байгууллагын нотолгоо баримт бичиг авсан байх тухай шаардлагыг хүчингүй болгох (Израиль);
32. ЛГБТИ хүмүүсийн эсрэг хэвшмэл, өрөөсгөл ойлголтын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлж, энэ бүлгийн эсрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхах аливаа үйлдлийг мөрдөн шалгах нөхцөлийг баталгаажуулах (Люксембург);
33. ЛГБТИ залуучуудын аюулгүй орчныг хангах, боловсролын байгууллага, эсхүл үе тэнгийнхэнээрээ шоовдорлуулахаас айгүйгээр хөгжих, өөрийгөө илэрхийлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаа зэрэг ойлголтыг багтаасан ялгаварлан гадуурхахын эсрэг бодлогыг нэвтрүүлэх (Нидерланд);
34. Олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, хууль сахиулах байгууллагуудад үр дүнтэй сургалт зохион байгуулах замаар ЛГБТИ хүмүүсийн талаарх хэвшмэл, өрөөсгөл ойлголттой тэмцэх (Нидерланд);
35. Хүний эрх, ялгаварлан гадуурхах түүний дотор бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаагаар нь ялгаварлахтай тэмцэх сэдвээр эрүүл мэндийн ажилтнууд, шүүгч, цагдаагийн алба хаагчид, хорих байгууллагын ажилтнуудад сургалт зохион байгуулах (Португал);
36. Бэлгийн чиг баримжаагаар нь ялгаварлан гадуурхах, үзэн ядах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр шинээр бий болсон хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэх (Испани);
37. Тогтвортой хөгжлийн зорилт 5.2 ба 16.1–т нийцүүлэн гэр бүлийн хүчирхийлэл, ЛГБТИ бүлгийн эсрэг хүчирхийллийн талаар мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх арга хэмжээ авах (Швейцар);
38. ЛГБТИ хүмүүсийн эсрэг үзэн ядах гэмт хэрэгтэй холбоотой хэрэг зөрчлийн талаар хуульч, хууль сахиулах байгууллагын албан хаагчдыг үргэлжлүүлэн сургах, холбогдох хуулийн талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх (Австрали);
39. ЛГБТ хүмүүсийн талаарх өрөөсгөл ойлголтыг арилгах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломжийг хангах талаар хүчин чармайлт гаргахад анхаарах (Тайланд);
40. Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг арилгаж, гадаадын иргэдийн эсрэг үзэн ядах үг хэллэг хэрэглэх явдлыг багасгах (Египет);
41. Тогтвортой хөгжлийн 2020 оны хөтөлбөрийн холбогдох чухал зорилтыг

- биелүүлэхийн тулд ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн салбар хоорондын хэрэгжилтийг бэхжүүлэх (Куба);
42. 2019 онд эхлүүлсэн үйл явцыг үргэлжлүүлэн Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмыг хэрэгжүүлэх үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах хүчин чармайлтыг эрчимжүүлэх (Чили);
  43. НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмын дагуу Бизнес ба хүний эрхийн үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад холбогдох бүх этгээд, ялангуяа иргэний нийгмийг оролцуулах (Швейцар);
  44. Хүмүүс, ялангуяа малчид, тариаланчдын амьжиргаа, уламжлалт соёл, сайн сайхан аж амьдралыг хадгалахын тулд цэвэр орчин, цэвэр усаар хангагдах эрхийг хамгаалахад чиглэсэн хүчин чармайлтыг сайжруулах (Индонез);
  45. Ашигт малтмалын үйл ажиллагааны зөвшөөрөл олгох үйл явцад хүний эрх, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, төслийн нөлөөлөлд өртөх бүх хүнийг үнэлгээний үйл явцад үр дүнтэй оролцох нөхцөл боломжийг бүрдүүлэх (Чили);
  46. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцөөр хангах (Сенегал);
  47. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр болон байгаль орчны эрсдлийг бууруулах бусад холбогдох арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хүчин чармайлтаа нэмэгдүүлэх (Тайланд);
  48. Салбар дундын байгаль орчинд тулгамдсан асуудал, түүний дотор уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн эрсдлийг бууруулах тогтолцоог сайжруулахад шаардлагатай хууль, эрх зүйн орчинг бий болгож, бэхжүүлэх хүчин чармайлтыг эрчимжүүлэх (Фижи);
  49. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр зүй бусаар харьцсан тухай гомдлыг хүлээн авах, хянан шийдвэрлэх үр дүнтэй механизм бий болгох (Франц);
  50. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс тэр дундаа шүүгч, прокурор, болон ажилтнуудад зориулан сургал тогтмол явуулах замаар урьдчилан сэргийлэх арга хэмжээг бэхжүүлэх (Индонез);
  51. Эрүүдэн шүүх, хүний нэр төрийг гутаан доромжилсон хэргийг мөрдөн шалгах бие даасан байгууллага байгуулах (Мальдив);
  52. Хоригдсон хүмүүстэй зүй бус харьцсан тухай гомдол мэдээллийг мөрдөн шалгах хүчин чармайлтаа сайжруулах (Польш);
  53. Эрүүдэн шүүхтэй тэмцэх чиглэлээр хүчин чармайлтаа үргэлжлүүлэх, ингэхдээ хууль тогтоомжийн хүрээнд гомдол хянан шийдвэрлэх бие даасан механизм бий болгох, эрүү шүүлтийн талаарх гомдлыг хараат бусаар, шуурхай мөрдөн шалгах нөхцөлийг бүрдүүлэх (Румын);
  54. Эрүү шүүлтийн хэргийг мөрдөн шалгах бие даасан, үр дүнтэй гомдлын механизм бий болгох (Испани);
  55. Эрүү шүүлтийн талаар гомдол гаргах, гомдлыг мөрдөн шалгах механизмыг бэхжүүлж, үр дүнтэй байдлыг хангах (Ботсвана);

56. Хорих ангийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, хүний эрх чөлөөг хязгаарладаг бүхий л газарт хараат бусаар тогтмол хийх хяналт, шалгалтыг бэхжүүлэх (Норвеги);
57. Хорих ангийн хэт ачааллыг бууруулах чиглэлээр арга хэмжээ үргэлжлүүлэн авах (ОХУ);
58. Хүн худалдаалах гэмт хэргийг үр дүнтэй мөрдөн шалгах, ял шийтгэл оногдуулах, хохирогчдод илүү сайн үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хууль сахиулах болон шүүхийн тогтолцоог бэхжүүлэх (Канад);
59. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах, дэмжлэг туслалцаа үзүүлэх ажлыг үргэжлүүлэх (Иран);
60. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг бүхий хууль сахиулах байгууллагын ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулах (Ирак);
61. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг нөхөн сэргээх, хамгаалах байраар хангах зэрэг замаар хохирогчдын хамгаалалтыг сайжруулж, хохирлоо нөхөн төлүүлэх бололцоог бүрдүүлэх (Малайз);
62. Төрийн албан хаагчид, хууль сахиулах байгууллагын болон цагаачлалын ажилтнууд, прокуроруудад мэргэшлийн сургалт явуулах, хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн байцаах, яллах, шийтгэл оногдуулах, энэ гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах, дэмжлэг туслалцаа үзүүлэх замаар хүн худалдаалах гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх (Мексик);
63. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын хамгаалалтыг сайжруулж, хохирлоо нөхөн төлүүлэх арга механизмыг бүрдүүлэх (Нигер);
64. Орчин цагийн боолчлолын бүх хэлбэрийг гэмт хэрэгт тооцох чиглэлээр дотоодын хууль тогтоомжийг сайжруулан бэхжүүлэх, үүнд хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай НҮБ-ын протоколтой нийцүүлэн хүн худалдаалахыг гэмт хэрэгт тооцох (ИБУИНХУ);
65. Хүн худалдаалах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдаалахтай тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй үндэсний үйл ажиллагаа, хөтөлбөрүүдийг нэгтгэх чиглэлээр үргэлжлүүлэн ажиллах (Венесуэл);
66. Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, түүний дотор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.1-д нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг түргэтгэх замаар хохирогчид прокуророос хүн худалдаалах гэмт хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж байгаа этгээдүүдийн эсрэг хэрэг үүсгэсэн эсэхээс үл хамааран хамгаалах үйлчилгээ авах боломжтой байх нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарах (Бахам);
67. Төрийн албан хаагчдад зориулсан мэргэшлийн сургалт явуулах зэргээр хүн худалдаалах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдаалахтай тэмцэх, гэмт этгээдэд шийтгэл оногдуулах нөхцөлийг баталгаажуулж хууль сахиулах үйл ажиллагааг сайжруулах, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод иж бүрэн тусламж үзүүлэх, нөхөн сэргээх эмчилгээнд хамруулах зэрэг замаар хүчин чармайлтыг улам эрчимжүүлэх (Беларусь);
68. Шашин шүтэх, эс шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, үүнд хууль, эрх зүйн зохицуулалтын орчныг бүрдүүлж шашны бүлэг, байгууллагуудад чөлөөтэй бүртгүүлж, үйл ажиллагаа явуулах боломжийг олгох (АНУ);

69. Гүтгэх үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй байх арга хэмжээ авах зэрэг замаар сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан болон иргэний нийгмийн идэвхтнүүд ямарваа шийтгэл хүлээхээс айж эмээх зүйлгүйгээр үйл ажиллагаагаа олон улсын стандартын дагуу чөлөөтэй явуулах нөхцөлийг хангах (Эстони);
70. Зөрчлийн тухай хуулийн 6.21 дэх заалтыг хүчингүй болгох замаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах (ИБУИНХУ);
71. Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын эсрэг үйлдсэн халдлагын хараат бусаар мөрдөн шалгах нөхцөлийг баталгаажуулж, гэм буруутай нь тогтоогдсон этгээдэд шийтгэл хүлээлгэх (Австрали);
72. Хүний эрхийг хамгаалагчид, иргэний нийгмийн байгууллагуудыг заналхийлэх, айлган сүрдүүлэх, дарамтлахаас хамгаалсан хууль тогтоомж баталж, хэрэгжүүлэх, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын эсрэг үйлдсэн халдлагын хэргийг мөрдөн шалгах, буруутай этгээдэд хариуцлага оногдуулах (Чех);
73. Байгаль орчинд хор хохирол учруулснаас үүдэлтэй хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох (Франц);
74. Төрийн бус байгууллагын бүртгэл, санхүүжилтийн тухай зохицуулалтыг олон улсын стандартад нийцүүлэх үүднээс Төрийн бус байгууллагын тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулах (ХБНГУ);
75. Иргэний нийгэм, түүний дотор төрийн бус байгууллага, хүний эрхийг хамгаалагчид, шашны бүлгүүдийн улс төрийн үйл явц болон авлигын эсрэг хүчин чармайлтад оролцоог нь нэмэгдүүлэх (АНУ);
76. Хүний эрхийг хамгаалагчдыг халдлага, заналхийлэл, сүрдүүлгээс хамгаалах (Франц);
77. Хүний эрхийг хамгаалагчдын асуудлаарх Тусгай илтгэгчийн өгсөн зөвлөмжийн дагуу Хүний эрхийг хамгаалагчдын тухай хуулийн төслийг сайжруулах, батлах замаар хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах (ХБНГУ);
78. Хувь хүний нууцаа хамгаалуулах эрхийг хөхиүлэн дэмжиж, улам сайн хамгаалах зорилгоор өгөгдөл хамгаалах үр дүнтэй хууль тогтоомж батлах, ингэхдээ хуульд нийцсэн байх, зайлшгүй байх болон хязгаарлалтын хүрээ нь хэр хэмжээнд нийцсэн байх зарчмыг баримтлах (ХБНГУ);
79. Хүүхэд, ялангуяа бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн хувийн нууцаа хамгаалуулах эрхийг нь бүрэн баталгаажуулсан хууль, эрх зүйн орчин бий болгох (Бельги);
80. Шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлэх, ялангуяа 2019 оны 3 дугаар сард батлагдсан Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Прокурорын тухай болон Авлигын эсрэг хуульд тус тус оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүчингүй болгох (Франц);
81. Шүүхийн бие даасан байдал, үйл ажиллагааны ил тод, чөлөөт байдлыг баталгаажуулахад чиглэсэн арга хэмжээг үргэлжлүүлэн авах (Ирак);
82. Шүүхийн хараат бус, ил тод байдлыг хангах, хууль сахиулах үйл ажиллагаа тодорхой байх нөхцөлийг баталгаажуулахад чиглэсэн арга хэмжээг үргэлжлүүлэн авах (Япон)
83. Шүүхийн тогтолцооны хараат бус, бие даасан байдлыг бүрэн хангах талаар хүчин чармайлтаа үргэлжлүүлэх (Перу);

84. Алслагдмал нутаг дэвсгэрт хууль зүйн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх үүднээс хууль, эрх зүйн болон шүүхийн шинэтгэл хийх чиглэлээрх үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх (ОХУ);
85. Шүүхийн бие даасан байдлыг хамгаалах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авч, шүүгч, прокурорыг томилох үйл явцыг ил тод, хараат бус байлгах (Чех);
86. Хууль зүйн хамгаалалтыг тууштай хэрэгжүүлж, шүүгч болон бусад албан тушаалтныг дур зоргоор ажлаас нь халахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хамгаалалтын арга хэмжээ бий болгох зэрэг замаар шүүхийн бие даасан байдал, авлигын эсрэг хяналтыг бэхжүүлэх (АНУ);
87. Шүүхийн тогтолцооны хараат бус, бие даасан байдлыг хангахын тулд хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, журмыг шинэчлэх зэрэг арга хэмжээ авах (Бразил);
88. Шүүхийн шударга, ил тод байдлыг хангах, эрүүдэн шүүхэд оролцсон этгээдэд хариуцлага оногдуулах, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон интернетийн хэрэглээнд тогтоосон хязгаарлалтыг цуцлах талаар шаардлагатай хүчин чармайлт гаргах (Египет);
89. 2019 онд батлагдсан Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлж, Монгол Улсын үндэсний хөгжил дэвшил, ард иргэдийн сайн сайхан байдлыг хангахын тулд авлигатай тэмцэх чиглэлээрх хүчин чармайлтаа үргэлжлүүлэх (Индонез);
90. Шүүх засаглал, төрийн албан дахь авлигатай тэмцэх, авлигатай холбоотой аливаа хэргийг мөрдөн шалгах хүчин чармайлтаа эрчимжүүлэх (Люксембург);
91. Шүүх засаглал, төрийн албан дахь авлигатай тэмцэх хүчин чармайлтаа эрчимжүүлэх (Тимор–Лесте);
92. 2021 онд болох ерөнхийлөгчийн сонгуульд ардчилсан сонгуулийн үйл явцыг хангах (Эстони);
93. Нийгмийн халамжийн дэмжлэг шаардлагатай өрхүүдэд хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээгээ үргэлжлүүлэх (Мьянмар);
94. Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг сайжруулж иргэдийн эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг бодитой хангах чиглэлээр улам бүр хүчин чармайлт гаргах (БНАСАУ);
95. Ядуурлын түвшингээс доогуур амьдарч байгаа бүлэгт нийгмийн халамж үзүүлэхэд чиглэсэн бодлогыг үргэлжлүүлэх (Оман);
96. Иргэдийн зохистой орон байраар хангагдах эрхийг баталгаажуулахад онцгой анхаарч, ядууралтай тэмцэх, нийгмийн даатгалыг сайжруулах чиглэлээр илүү их арга хэмжээ авч хэрэгжүүлэх (Польш);
97. Ядуурлыг бууруулах, иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхийн тулд нийгэм, эдийн засгийн хөгжлийг үргэлжлүүлэн дэмжих (БНХАУ);
98. Хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хууль, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Олон улсын хөдөлмөрийн байгууллагын зөвлөмжийн дагуу ажлын байрны бэлгийн дарамтыг хориглох тухай заалт оруулах асуудлыг судлан үзэх (Эстони);
99. Малчид, залуучуудын дунд ажилгүйдлийн түвшинг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээгээ сайжруулах (Мьянмар);

100. Нийтийн эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээг улам бүр сайжруулах (БНХАУ);
101. Эх нялхсын эрүүл мэндийн салбарт гарсан томоохон ахиц дэвшлийг үргэлжлүүлж, өдгөө хэрэгжиж буй бодлого стратегийг цааш үргэлжлүүлэн нэн ялангуяа нярай хүүхдийн асаргаа, нөхөн үржихүйн эрүүл мэнд, дархлаажуулалт, хөхөөр хооллолтыг дэмжих зэрэг чиглэлээрх хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх (Куба);
102. Эх, хүүхдийн эрүүл мэндийг хөхиүлэн дэмжих хүчин чармайлтаа үргэлжлүүлэх (Оман);
103. Үндэсний эрүүл мэндийн дэд бүтцийг нэн ялангуяа эх, хүүхдийн эрүүл мэндийн салбарт үргэлжлүүлэн бэхжүүлэх (Венесуэл);
104. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн талаархи насны онцлогт тохирсон боловсролыг сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгах (Фижи);
105. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тухай мэдээлэл, бараа, үйлчилгээ авах бололцоог бүрдүүлэх замаар охид, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийг хамгаалах, хүчээр үр хөндүүлэх, албадан үргүйжүүлэх явдлыг таслан зогсоох (Исланд);
106. Хүүхдийн насны онцлогт тохирсон бэлгийн боловсрол олгох цогц сургалтын хөтөлбөр баталж ерөнхий боловсролын сургалтын туршид хэрэгжүүлэх, уг хөтөлбөрт хүчирхийллийн асуудлыг мөн тусгаж оруулах (Исланд);
107. Бүх эмэгтэйчүүд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээлэл, үйлчилгээ авах бололцоог бүрдүүлж, тэд эдгээр бүх үйл явцад шийдвэрээ мэдээллийн үндсэн дээр чөлөөтэй гаргах эрхийг нь хангах (Мексик);
108. 2021–2030 оны Боловсролын салбарын мастер төлөвлөгөөг батлах чиглэлээр үргэлжлүүлэн ажиллах (Киргиз);
109. “Нэг Монгол” үндэсний нээлттэй боловсролын хөтөлбөрийг орчин үеийн боловсролын арга барил, интернет ашиглан насан туршийн боловсрол олгоход чиглэсэн шинэ технологиор баяжуулан бэхжүүлэх (Венесуэл);
110. Эмзэг бүлгийн хүүхдүүдэд онцгой анхаарал хандуулах замаар бүх түвшний хүүхдүүд боловсролд тэгш хамрагдах боломжийг баталгаажуулах чиглэлээр хүчин чармайлтаа бэхжүүлэх (Мальдив);
111. Үндэстний болон хэлний цөөнх, түүнчлэн уугуул иргэдийн боловсролын хүртээмжийг үргэлжлүүлэн бэхжүүлэх (Перу);
112. Боловсролын салбарын мастер төлөвлөгөөг шуурхай эцэслэж, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахын тулд холбогдох талуудтай зөвшилцөн олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаа явуулах (Сингапур);
113. Хүртээмжтэй боловсролын ерөнхий бодлогыг боловсруулах болон боловсрол, ялангуяа дээд боловсрол эзэмших эрхээ эдлэхэд нь хүн бүрт тэгш боломж олгох чиглэлээрх хүчин чармайлтаа үргэлжлүүлэх (Тунис);
114. Эрүүгийн хууль, Хөдөлмөрийн тухай хуульд бэлгийн болон ажлын байрны дарамтыг хориглохтой холбоотой нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг замаар охид, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалахад чиглэсэн цогц хууль тогтоомж батлах (Ирланд);
115. Эмэгтэйчүүд эдийн засгийн хувьд илүү хараат бус байх нөхцөлийг бүрдүүлж, бэхжүүлэх ажлыг үргэлжлүүлж, тэдний эдийн засгийн салбарт өрсөлдөх явдлыг хөхиүлэн дэмжиж, эмэгтэйчүүдийн эсрэг хөдөлмөрийн ялгаварлан гадуурхалтыг

- хориглох арга хэмжээ авах (Энэтхэг);
116. Эмэгтэйчүүдийг санхүүгийн хувьд бие даахад нь туслах таатай орчин бүрдүүлэх чиглэлээр хүчин чармайлтаа эрчимжүүлэх, ялангуяа ажлын байранд эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахыг хориглох талаар төрийн албан хаагчид болон хувийн хэвшлийн ажилтнуудын мэдлэгийг дээшлүүлэх (Люксембург);
117. Эмэгтэйчүүдийг эдийн засгийн хувьд бие даахад нь туслах таатай орчин бүрдүүлэх чиглэлээр хүчин чармайлтаа эрчимжүүлэх, үүнд мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх ажил зохион байгуулах, мэргэжлийн болон техникийн сургалт явуулах (Монтенегро);
118. Охид, эмэгтэйчүүдийг хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдлийг арилгах үүднээс охид, эмэгтэйчүүд, тэдний гэр бүлийн боловсрол хийгээд эдийн засгийн нөхцөл бололцоог дээшлүүлэхэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлж бэхжүүлэх (Филиппин);
119. Нийгэмд жендэрийн тэгш байдлыг хөхиүлэн дэмжих чиглэлээр нэмэлт арга хэмжээ авах, түүний дотор 2011 онд батлагдсан Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг түргэтгэх (Япон);
120. Жендэрийн тэгш байдлыг хөхиүлэн дэмжихэд салбар хоорондын болон төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг үргэлжлүүлж, ажлын байран дахь жендэрийн саад тотгор, өрөөсгөл ойлголтыг даван туулах практик арга хэрэгслээр дамжуулан эмэгтэйчүүдийг чадавхижуулах сургалтын хөтөлбөр боловсруулахад олон улсын холбогдох түншүүдтэй хамтран ажиллах (Сингапур);
121. Жендэрийн тэгш байдлыг бэхжүүлэх, охид, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахтай тэмцэх, түүний дотор эрүүл мэндийн анхан шатны тусламж, нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрхийг хангах талаар хүчин чармайлтаа үргэлжлүүлэх (Тунис);
122. Эмнэлзүйн удирдамж, эмчилгээний стандартаас охид, эмэгтэйчүүдийг бэлгийн харьцаанд орсон эсэхийг тодорхойлохтой холбоотой шаардлагыг хасч, тэдний эрхийг хангах (Австрали);
123. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, ялангуяа гэр бүлийн хүчирхийлэл болон бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр төрөөс хууль эрх зүйн хамгаалалт, үйлчилгээ үзүүлэх, мэдээллийн хүртээмжтэй байдал, олон нийтэд хүргэх чиглэлээр ахиц дэвшил гаргахыг үргэлжлүүлэх (Чили);
124. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт, түүний дотор гэр бүлийн хүчирхийлэл болон бэлгийн дарамттай тэмцэхэд чиглэсэн хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийг бүрэн, үр дүнтэй хэрэгжүүлэх (Итали);
125. Аливаа хэлбэрийн хүчирхийллийн хохирогч болсон охид, эмэгтэйчүүдэд туслах арга хэмжээг бэхжүүлэх, үүнд хоргодох байр, хохирогчдод дэмжлэг, тусламж үзүүлэх үйлчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлэх (Мьянмар);
126. Хүүхэд, эмэгтэйчүүдийг хүчирхийллийн бүх хэлбэрээс хамгаалахад чиглэсэн арга хэмжээг бэхжүүлэх (Сенегал);
127. Охид, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл болон бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг үргэлжлүүлэн авах (Энэтхэг);
128. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн түгээмэл хэлбэр, ялангуяа гэр бүлийн хүчирхийлэл болон бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх хүчин чармайлтаа эрчимжүүлж, хохирогчдод зохих дэмжлэг, тусламж үйлчилгээ үзүүлэх (Чех);

129. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх арга хэмжээ авах, үүний дотор цагдаагийн алба хаагчдыг хохирогч төвтэй аюул заналхийллийн үнэлгээг хэрхэн үр дүнтэй хийх талаар сургаж дадлагажуулах (Дани);
130. Гэр бүлийн хүчирхийлэл болон жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хүчин чармайлтаа үргэлжлүүлэх, ялангуяа хууль сахиулах үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх ажил зохион байгуулах, хөрөнгө хуваарилах, түүнчлэн хүчирхийллээс амьд үлдсэн хүмүүсийн хамгаалалт болон үйлчилгээ авах нөхцөл боломжийг сайжруулах (Канад);
131. Бэлгийн дарамтад өртсөн хохирогчдын хувийн нууцыг хамгаалах хууль, эрх зүйн орчин бий болгож, хохирогчдыг нөхөн сэргээх зорилгоор аюулгүй орон байраар хангах, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх (Эстони);
132. Гэр бүлийн хүчирхийлэл болон жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулах, гэр бүлийн хүчирхийлэл болон жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн охид, эмэгтэйчүүдийн онцгой хэрэгцээний талаарх хууль сахиулах байгууллагын ажилтнууд, хуульчид, шүүгчдийн мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээ авах (Фижи);
133. Гэр бүлийн хүчирхийлэл болон жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчдод зохих дэмжлэг туслалцаа үзүүлэхэд чиглэсэн хамгаалалтын механизмыг улам бэхжүүлэх (Филиппин);
134. Гэр бүлийн хүчирхийлэл болон жендэрт суурилсан хүчирхийлэл, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг арилгах, парламент болон шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог улам бүр нэмэгдүүлэх чиглэлээр хүчин чармайлтаа үргэлжлүүлэх (БНСУ);
135. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бүх хохирогчийг хамгаалах чиглэлээрх үндэсний механизмуудыг улам бүр бэхжүүлэх (Киргиз);
136. Гэр бүлийн хүчирхийлэл болон жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг үргэлжлүүлэн авах (Непал);
137. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хамгаалах байр, хохирогчдыг дэмжих үйлчилгээнд хамрагдах боломжийг өргөжүүлж, холбогдох ажилтнуудад тэдний онцлог хэрэгцээ, эмзэг байдлын талаар зохих сургалтыг зохион байгуулах (Бахам);
138. Шийдвэр гаргах үйл явцад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх (Иран);
139. Жендэрийн тэгш байдлыг хөхиүлэн дэмжих, Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрөөр дамжуулан шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хүчин чармайлтаа үргэлжлүүлэх (Лаос);
140. Улс төрийн болон шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хүчин чармайлтыг үргэлжлүүлэн (Непал);
141. Хүүхдийн эрхийн хамгаалалтыг бэхжүүлэхэд чиглэсэн хүчин чармайлтыг бүх түвшинд үргэлжлүүлэх (Ливан);
142. Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг бэхжүүлэх чиглэлээр нэмэлт авах арга хэмжээ авах, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсрол эзэмших бүрэн боломжийг бүрдүүлэх, хүүхдүүдийг хөдөлмөрийн хортой нөхцөлд ажиллуулах явдлыг таслан зогсоох (Польш);



143. Хүүхдийг кибер гэмт хэргээс хамгаалах зорилгоор мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх (Сири);
144. Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээрх хүчин чармайлтаа үргэлжлүүлэх (Вьетнам);
145. Бүх түвшний хүүхдүүд, түүний дотор алслагдмал нутаг дэвсгэрт амьдардаг болон амьжиргааны түвшнээс доогуур орлоготой өрхийн хүүхдүүдэд боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлэх талаар тодорхой арга хэмжээ авах (Украйн);
146. Эмзэг, гадуурхагдсан бүлгийн хүүхдүүдэд онцгой анхаарал хандуулж, хүүхэд бүрт боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлэх (Афганистан);
147. Хүүхдийн эндэгдлийн түвшинг улам бууруулах зорилгоор хүүхдийн эрүүл мэндийн хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх (Иран);
148. Хөдөө орон нутгийн болон бага орлоготой өрхийн хүүхдүүдэд онцгой анхаарал хандуулж, хүүхэд бүр эрүүл мэндийн зохих тусламж үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авах (Афганистан);
149. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх хүчин чармайлтаа бэхжүүлэх (Ирак);
150. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэр, түүний дотор гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хүчин чармайлтаа ахиулах (Итали);
151. НҮБ-ын Хүүхдэд зориулсан халамжийн хувилбарт үйлчилгээний тухай удирдамж болон Ерөнхий тайлбар №6-г харгалзан үзэж хувилбарт үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдүүдэд чанартай халамж үйлчилгээ үзүүлэх, гэр бүлийг дэмжих үйлчилгээг бий болгож, сайжруулах, нийгмийн үйлчилгээ эрхлэгчдэд зориулж чанартай сургалт зохион байгуулах, хүүхэд эцэг эхээсээ шаардлагагүйгээр хагацахаас урьдчилан сэргийлэх (Словени);
152. Хүүхдийн хөдөлмөр, хүүхдийн эсрэг гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх нэмэлт арга хэмжээ авах, тухайлбал урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүдийн санхүүжилтийг нэмэгдүүлэх (ХБНГУ);
153. Хүүхдийг аюултай орчинд ажиллуулахгүй байх нөхцөлийг баталгаажуулж, хүүхдийн хөдөлмөр, хүүхдийн мөлжлөгтэй тэмцэх (Итали);
154. Хүүхдийг бие махбодийн болон сэтгэлзүйн хүчирхийллээс хамгаалах, хүүхэд аюултай, хортой нөхцөлд хөдөлмөр эрхлэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хүчин чармайлтаа нэмэгдүүлэх (БНСУ);
155. Хүүхдийн эрхийн хамгаалалтыг сайжруулахад чиглэсэн хүчин чармайлтаа бэхжүүлэх, ялангуяа хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, насанд хүрээгүй хүүхдийг бэлгийн мөлжлөгт хамруулах чиглэлээр (Румын);
156. Хүүхдийн хөдөлмөрийг устгахад чиглэсэн Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө батлах, хүн хүч, техник, санхүүгийн хангалттай нөөцөөр хангах (Бельги);
157. Төрсний бүртгэлийг хүүхдийн хувийн байдал, насыг бүртгэх зориулалтынх нь хувьд боловсронгуй болгож, Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт хөдөлмөрийн хяналт шалгалтын дэглэмийг сайжруулах замаар хүүхдийн хөдөлмөрийг мөлжихөөс урьдчилан сэргийлэх засаглалын механизмыг бэхжүүлэх (Ботсвана);
158. Хууль, олон нийтийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх замаар гэр бүл болон сургуулийн орчинд бие махбодийн шийтгэлийг таслан зогсоох чиглэлээр хүчин чармайлтаа нэмэгдүүлэх (Монтенегро);

159. Хүн, ялангуяа хүүхэд худалдаалахтай тэмцэх чиглэлээр хүчин чармайлтаа үргэлжлүүлэх (Тунис);
160. Хүүхдийг бүх төрлийн хүчирхийлэл, мөлжлөг, ялангуяа хүүхдийн хөдөлмөрөөс хамгаалах талаар арга хэмжээ үргэлжлүүлэн авах (Норвеги);
161. Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ажлын байрыг нэмэгдүүлэх, ажлын орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр хүчин чармайлтаа үргэлжлүүлэх (Гүрж);
162. Сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийг албадан эмчлэх, гутаан доромжлох, хүчирхийлэл үйлдэх, дарамт шахалт үзүүлэх, хэт их эмчилгээ хийхтэй тэмцэх, тэднийг нийгэмд нэгдэн амьдрахыг нь дэмжиж сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх зэрэг арга замаар Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын дагуу сэтгэцийн болон нийгмийн сэтгэцийн эмгэгтэй хүмүүст дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн ээлтэй, халамжийн хувилбарт үйлчилгээ бий болгох, тэдгээр хүмүүсийн шийдвэрээ мэдээллийн үндсэн дээр, чөлөөтэй гаргах эрхийг нь хүндэтгэн хангах (Португал);
163. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхах, тэгш бус байдалтай тэмцэх стратеги боловсруулж, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцыг бүрэн хэрэгжүүлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудтай зөвлөлдөх албан ёсны, байнгын механизм бий болгох (Испани);
164. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээг сайжруулах (Сири);
165. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах чиглэлээр амжилттай хэрэгжүүлж буй үндэсний бодлогыг үргэлжлүүлэх (Венесуэл);
166. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд, хөвгүүдийн эрхийг хангахад чиглэсэн хүчин чармайлтыг нэмэгдүүлэх (Аргентин);
167. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг (үүнд, алслагдмал бүс нутагт амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол эзэмших эрх багтана) хамгаалах, хөхиүлэн дэмжих, чиглэлээрх хүчин чармайлтыг үргэлжлүүлэх (Япон);
168. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нийгмийн амьдралд оролцох нөхцөлийг баталгаажуулах, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрхийг хөндөж буй шийдвэр гаргах үйл явцад тэдний оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх (Норвеги);
169. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд цогц хөгжлийн дэмжлэг үзүүлэх бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх (Оман);
170. Холбогдох олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг, албадан гаргахгүй байх зарчмыг биелүүлж орогнол хүсэгчдийг хамгаалах чиглэлээр зохих арга хэмжээ авах, Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай 1951 оны конвенцод нэгдэн орох (БНСУ).

**Онцолсон зөвлөмжүүд:**

1. Эрүү шүүлтийн эсрэг хорооны гомдол, мэдээлэл хүлээн авч шийдвэрлэх бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх (Украин);
2. Бүх цагаач ажилчин болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийг хамгаалах тухай олон

- улсын конвенцод гарын үсэг зурж, соёрхон батлах (Гондурас);
3. Бүх цагаач ажилчин болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийг хамгаалах тухай олон улсын конвенцийг соёрхон батлах (Филиппин);
  4. Бүх цагаач ажилчин болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийг хамгаалах тухай олон улсын конвенцийг соёрхон батлах (Сенегал);
  5. Гэрийн үйлчилгээний ажилчдын тухай ОУХБ-ын 189 дүгээр конвенцийг соёрхон батлах (Филиппин);
  6. Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенцод нэгдэн орох (Эль Сальвадор);
  7. Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай 1951 оны конвенц, түүний 1967 оны Протоколыг соёрхон батлах (Афганистан);
  8. Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай 1951 оны конвенц, түүний 1967 оны Протоколыг соёрхон батлах, холбогдох хууль тогтоомж батлах, үйлчилгээ авах боломжоор хангах зэрэг замаар дүрвэгч, орогнол хүсэгчдийг хамгаалах (Канад);
  9. Иргэний харьяалалгүй хүмүүсийн эрх зүйн байдлын тухай конвенц болон Иргэний харьяалалгүй байдлыг бууруулах тухай конвенцийг тус тус соёрхон батлах (Бразил);
  10. Иргэний харьяалалгүй хүмүүсийн эрх зүйн байдлын тухай 1954 оны конвенц болон Иргэний харьяалалгүй байдлыг бууруулах тухай конвенцод тус тус гарын үсэг зурж, соёрхон батлах (Гондурас);
  11. Цөөнхийн бүлгүүд, түүний дотор үндэсний цөөнх, уугуул иргэд болон ЛГБТИ бүлгийн эрхийг хамгаалах зорилгоор ялгаварлан гадуурхалтын эсрэг цогц хууль батлах (Канад);
  12. Ижил хүйстэн хосыг хуулиар хамгаалах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд тэдний гэрлэлтийг хуулиар хүлээн зөвшөөрөх асуудлыг авч үзэх (Люксембург);
  13. Гэр бүлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар ижил хүйстэн хосын гэрлэлтийг хуулиар хүлээн зөвшөөрч, хамгаалах (Дани);
  14. Үндсэн хуулиас цаазаар авах ялын тухай заалтыг халах талаар шаардлагатай арга хэмжээг авах (Румын);
  15. 2015 оны Эрүүгийн хуульд заасанчлан бүх төрлийн гэмт хэрэгт цаазаар авах ял оногдуулахгүй хэвээр байх нөхцөлийг баталгаажуулж, Үндсэн хуулиас цаазаар авах ялын тухай заалтыг халах (Чех);
  16. Үндсэн хуулиас цаазаар авах ялын тухай заалтыг халах (Испани);
  17. Үндсэн хуулиас цаазаар авах ялын тухай аливаа заалтыг халах (Бельги);
  18. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нийгмээс тусгаарлахгүй байх нөхцөлийг баталгаажуулах чиглэлээр нэмэлт арга хэмжээ авах (Тимор-Лесте);
  19. Цагаачид Монгол Улсын ажилчдын нэгэн адил хөдөлмөрийн орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор үр дүнтэй хяналтын механизм бий болгох замаар цагаач ажилчдын ажиллаж амьдрах нөхцөлийг сайжруулах (Нижер);
  20. Бүх цагаач ажилчин болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийг хамгаалах тухай олон улсын конвенцийг соёрхон баталж, цагаач ажилчид Монгол Улсын ажилчдын нэгэн адил эрх эдлэх зохих нөхцөл бүрдүүлэх, хүн худалдаалахтай тэмцэхэд анхаарал хандуулах (Египет).



АРАВДУГААР БҮЛЭГ

**НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ  
БАЙГУУЛЛАГЫН  
ТУСГАЙ ИЛТГЭГЧ  
НАРЫН ТАЙЛАН**

## 10.1 НҮБ–ЫН ХООЛ ХҮНСЭЭР ХАНГАГДАХ ЭРХИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН ТУСГАЙ ИЛТГЭГЧ ЖАН ЗИГЛЕРИЙН ТАЙЛАН

2005 оны 3 дугаар сарын 08–ны өдөр

E/CN.4/2005/47/Add.2

### МОНГОЛ УЛС ДАХЬ АЙЛЧЛАЛ<sup>1 \*\*</sup>

#### Товч мэдээлэл

Хоол хүнсээр хангагдах эрхийн асуудлаарх НҮБ–ын Тусгай илтгэгч 2004 оны 8 дугаар сарын 14–24–ний өдрүүдэд Монгол Улсад айлчлав. Түүний айлчлах болсон зарим нэг шалтгаан нь саяхан Монгол орны мал сүргийг хэдэн мянган тоо толгойгоор хороосон хахир хүйтэн өвөл болон НҮБ–ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын (ХХААБ) мэдээлснээр Монгол Улс нь хоол тэжээлийн дутагдалтай үзүүлэлтээр Азид хамгийн дээгүүрт орсон байгаагаас үүдэлтэй юм.

Уг илтгэлээр хахир хүйтэн өвөл болон зуднаас гарах үр дагаврыг авч үзэж, Монгол Улс дахь хоол тэжээлийн дутагдал, хүнсний гачигдал болон ядуурлын түвшинд үнэлэлт өгнө. Түүнчлэн Монгол Улс дахь хоол хүнсээр хангагдах эрхийг зохицуулах хуулийн хүрээ болон хоол хүнсээр хангагдах эрхийг хэрэгжүүлэх Монгол Улсын хүлээсэн үүрэгтэй Засгийн газрын бодлого, хөтөлбөрүүд хэрхэн нийцэж байгааг судалсан болно. Үүний дараа хоол хүнсээр хангагдах эрхийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс болон гол мэдээ баримтуудыг нягталсан.

Хоол хүнсээр хангагдах эрхийн талаар илүү ойлголт авахыг хүссэн Засгийн газрын нээлттэй байдал нь Тусгай илтгэгчийн талархлыг хүлээсэн. Хүний эрхийг хэрэгжүүлэх орчин сайжирч, Хүний эрхийн Үндэсний Комиссоос эдийн засаг, нийгэм, соёлын эрхэд тавьж буй хяналт түүний хувьд сайшаалтай байсан билээ. Мөн хоол хүнсний хүртээмж болон хүнсний аюулгүй байдлын талаар авч үзэх Засгийн газрын бодлого болон боловсруулалтад ахиц дэвшил гарч байгааг Тусгай илтгэгч сайшаасан билээ.

Гэвч Тусгай илтгэгч Монгол Улс дахь хүнсний баталгаагүй байдал болон хүнсний хүртээмж муу байгаа асуудлыг төдийлэн авч хэлэлцэхгүй байгааг илтгэлдээ онцлон тэмдэглэсэн байна. Засгийн газрын бодлого, хөтөлбөрүүдэд хоол тэжээлийн асуудалд ихээхэн анхаарал хандуулсан ч, хоол хүнсний хүртээмж болон байнгын хоол тэжээлийн дутмаг байдалд төдийлөн анхаарал хандуулаагүй байна.

Ядуурлын түвшин дэх судалгаагаар байнгын хоол хүнсний дутагдалтай байх явдал нь Монгол Улсад тулгамдаж буй ноцтой асуудал болохыг харж болох ч хүнсний баталгаагүй байдал болон хоол тэжээлийн дутмаг байдлын асуудлаар цөөн тооны

<sup>1</sup> Уг товчлолыг бүх хэлээр хөрвүүлэн гаргасан болно. Илтгэлийг зөвхөн нийтлэх хэлээр хүргүүлж байна.

\*\* Сүүлийн үеийн мэдээллийг хүргэх үүднээс уг илтгэлийг хожимдож өргөн барьсан болно.

судалгаа явуулсан байна. 1990 оноос өмнө Монгол Улсад ядуурал, хоол хүнсээр дутагдах гэсэн ойлголт байгаа бол өнөөдөр Монгол Улсын хүн амын гуравны нэгээс илүү хувь нь байнгын хоол хүнсний дутагдалтай бөгөөд ядуурлын түвшин өндөр байгаа нь зохистой хоол хүнсээр хангагдах явдалд сөргөөр нөлөөлж байна.

1990 оноос чөлөөт эдийн засгийн зах зээлд шилжсэн нь хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, дотоод дахь үйлдвэрлэл зогсож, бэлчээрийн мал аж ахуй эрхлэх явдал багасч, үүний улмаас ядуурал эрчимтэй өсч, баян хоосны ялгаа гарсан байна.

Хэдийгээр, Монгол Улс нэг хүнд оногдох хөгжлийн тусламж хүлээн авдаг улсуудын дунд дэлхийд дээгүүрт ордог ч, ядуурал, хоол тэжээлийн дутагдлын түвшин ихэсч байгаа нь хоол хүнсээр хангагдах эрхийг хэрэгжүүлэхэд саад болж байна. Иймд, хоол тэжээлийн дутагдал, хүнсний баталгаагүй явдал болон хоол хүнсний хүртээмжгүй байдлыг бүрэн дүүрэн тодорхойлох судалгаа яаралтай явуулахыг уг илтгэлээр зөвлөж байна.

Хоол хүнсээр хангагдах эрхийг хэрэгжүүлэх явдлыг сайжруулах болон хоол хүнсээр хангагдах эрхийн хэрэгжилтийг сааруулж буй нөхцлийг арилгах Засгийн газрын бодлого боловсруулах хэрэгтэй. Хоол хүнс болон ундны усны хүртээмжийн асуудлыг хариуцах холбогдох газруудын үүрэг хариуцлагыг тодорхой болгох хэрэгтэй.

Олон улсын тусламж нь ядуурал болон хүнсний баталгаагүй байдлыг бууруулахад чиглэгдсэн байх хэрэгтэй. Хөдөө орон нутаг дахь бэлчээрийн мал аж ахуйд тусгайлсан дэмжлэг үзүүлэх, тухайлбал малчдын хэрэгцээнд зориулж малын хашаа, тэжээл, хадлан зэрэгт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь зүйтэй. Бэлчээрийн газрыг өмчлүүлэх хэрэггүй бөгөөд харин нийтийн өмчлөлийн хууль тогтоомжийг сахиулснаар малын бэлчээрийн хомсдлыг бууруулж, бэлчээрийн мал аж ахуйд суурилсан амьжиргааны тогтвортой байдлыг нэмэгдүүлэх болно.

Хотжсон газруудад зохих ажлын байр бий болгох, ядуурлыг бууруулах тогтвортой хөгжлийг хангах асуудлыг голлон авч үзэх шаардлагатай. Монгол Улсад тулгардаг байнгын саад бэрхшээл болох далайд гарцгүй байдлыг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрүүлж, чөлөөт худалдааны зах зээл нь зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг хэрэгжүүлдэг байх үүд хаалгыг нээх шаардлагатай юм.

## **ХООЛ ХҮНСЭЭР ХАНГАГДАХ ЭРХИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН ТУСГАЙ ИЛТГЭГЧ ЖАН ЗИГЛЕРИЙН МОНГОЛ УЛСАД ХИЙСЭН АЙЛЧЛАЛЫН ТАЙЛАН**

*(2004 оны 8 дугаар сарын 14–24)*

### **Оршил**

1. Энэхүү айлчлалыг зохион байгуулахад Монгол Улсын Засгийн газар бүрэн дүүрэн дэмжлэг туслалцаа үзүүлж, хамтран ажилласанд Тусгай илтгэгч талархлаа илэрхийлж байна. Монгол Улсаас НҮБ-ын Тусгай илтгэгч нарт хүрэлцэн ирэх нээлттэй урилгыг 2004 оны 4 дүгээр сарын 9-нд илгээсэн бөгөөд Тусгай илтгэгч энэхүү урилгыг хүлээн авч Монгол Улсад айлчлах анхны Тусгай илтгэгч болсондоо баяртай байв. Тэрбээр Монгол

Улсаас Женев дэх Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Хасбазарын Бэхбат, Монгол Улсын Гадаад хэргийн яам болон ноён Бат-Очирын Эрдэнэбулган нарт тусгайлан баярлаж талархсанаа илэрхийлж байна. Мөн тэрбээр Монгол Улс дахь НҮБ-ын баг, ялангуяа Суурин төлөөлөгчийн дэд зохицуулагч ноён Роберт Хаган, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын (ДЭМБ) төлөөлөгч болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн (НҮБХХ) удирдлагын ахлах багт талархсанаа илэрхийлж байна. Тэрбээр НҮБХХ-ийн Суурин зохицуулагчийн газрын ноён Массоуд Хедешийн тусалсан явдалд талархлаа тусгайлан илэрхийлж байна. Түүний энэхүү айлчлалыг зохион байгуулахад тусалж дэмжсэн НҮБ-ын Хүний эрхийн Дээд комиссарын газарт мөн талархал илэрхийлж байна.

2.Тусгай илтгэгчийн айлчлалын үеэр, түүнийг Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч Чүлтэмийн Улаан, Хүнс, хөдөө аж ахуйн яам болон Эрүүл мэндийн сайд зэрэг Засгийн газрын хүндэт гишүүд болон Нийгэм хамгаалал, хөдөлмөр хангамжийн яам болон Хууль зүй, дотоод хэргийн яам зэрэг Засгийн газрын холбогдох бусад яамны ахлах мэргэжилтнүүд хүлээн авсан нь түүний хувьд хүндэтгэлтэй хандсан хэрэг байв.

Мөн тэрбээр Гамшигтай тэмцэх газрын ахлах ажилтнууд хүлээн авч уулзсанд талархлаа илэрхийлэв. Тэрбээр Улаанбаатар хотын удирдлагуудтай хийсэн уулзалтад мөн талархаж байна. Айлчлалынхаа үеэр, Тусгай илтгэгч Сэлэнгэ аймаг болон Дундговь аймгуудаар айлчлав. Тэрбээр Сэлэнгэ аймгийн Засаг дарга Ж.Баярмагнай болон Дундговь аймгийн Засаг дарга Ж.Адьяа нараас үзүүлсэн туслалцаанд талархсанаа илэрхийлж байна.

3. Тусгай илтгэгч болон түүний багийг дотоод болон гадаадын олон байгууллага хүлээн авсан нь тэдний хувьд хүндэтгэлтэй хандсаны илэрхийлэл байв. Тэрбээр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Ж.Дашдоржтой уулзан санал солилцож, мөн Комиссын бусад гишүүдтэй уулзсанд онцгойлон талархал илэрхийлэв. Мөн тэрбээр Монгол Улсад ажиллаж буй төрийн бус байгууллага, тухайлбал Хүний эрх хөгжил төв, Дэлхийн зөн, “Эй Си Эф” (Аксион Контре ла Файм) буюу “Өлсгөлөнгийн эсрэг хөдөлгөөн” олон улсын хүмүүнлэгийн байгууллага болон Их Британий “Хүүхдийг ивээх сан”-ийн зүгээс түүнтэй уулзах цаг гаргаж, мэдээллээр хангасанд талархлаа илэрхийлж байна. Түүнчлэн олон улсын хандивлагч байгууллагууд, ялангуяа Швейцарийн хөгжлийн агентлаг тусалж дэмжсэнд талархсанаа уламжилж байна.

4. Монгол Улс нь тал хээр нутагтай үзэсгэлэнт орон бөгөөд хойд зүгтээ Тайгын, баруун зүгтээ Алтайн мөнх цаст уулстай, өмнө зүгтээ Монгол орны гуравны нэгийг хөндлөн огтлох говь тал нутагтай билээ. Монгол Улс нь хойд зүгтээ Оросын Холбооны Улс, өмнө зүгтээ Хятад улс, баруун зүгтээ Казакстан зэрэг томоохон хөрш орнуудтай хиллэх далайд гарцгүй өргөн уудам нутагтай орон билээ. Монгол Улс нь хүн амын хамгийн бага нягтшилтай, 2.6 сая хүн амтай 1.5 сая квадрат километр газар нутагтай орон юм.

Зун нь богино, хуурай халуун уур амьсгалтай ч өвөл нь урт, хүйтэн, –30 цельсийн хэмээс ч илүү хүйтрэх эрс тэс уур амьсгалтай. Нийт хүн амын 40 орчим хувь нь хүн ам сийрэг суурьшсан хөдөө орон нутагт амьдрах бөгөөд тэнд хагас нүүдэлчин амьдралаар эсгий гэрт амьдарч, тэмээ, үхэр, адуу, хонь, ямаа зэрэг таван хошуу мал маллаж,



бэлчээрийн мал аж ахуй эрхлэн амьдардаг ард түмэн юм. Хүн амын бусад 60 орчим хувь нь хот суурин газар болон аймгийн төвүүдэд оршин суух бөгөөд нийт хүн амын гуравны нэгээс илүү хувь нь нийслэл хот Улаанбаатарт амьдарч байна.

5. XIII зууны үед, Чингис хаан болон Хубилай хааны үеийн Монгол гүрэн одоогийн Бээжингээс Каспийн тэнгис хүртэл газар нутгийг эзлэж байсан түүхтэй. Хожим Хятадын дарангуйлалд орсон ч, 1911 онд Монгол Улс тусгаар тогтнолоо олж, дараа нь 1921 онд Зөвлөлт Холбоот Улсын нөлөөгөөр коммунист засаглалтай улс болсон юм. Зөвлөлт Холбоот Улс их хэмжээний тусламж дэмжлэг үзүүлсний үндсэн дээр Монгол Улс хагас хотжиж, мөн үйлдвэржилтийн эхлэлийг тавьсан. Хэдийгээр амьжиргааны түвшин доогуур байсан ч 1990 он хүртэл ядуурлын туйл гэсэн ойлголт Монгол Улсад байгаагүй бөгөөд боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, нийгмийн халамж, тэтгэвэр тэтгэмжийг бүх нийтээр хүртэж байсан. Харин 1990 оны эхээр Зөвлөлт Холбоот Улс болон Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл нуран унаснаар Монгол Улсад үзүүлэх тусламж дэмжлэг, зах зээл үгүй болж Монгол орны эдийн засаг үндсэндээ уналтанд орсон. Үүнээс үүдэн Монгол Улсын үндэсний орлого, амьжиргааны түвшин огцом доройтож, дундаж орлоготой орон байснаа бага орлоготой орон буюу “Социалист системийн орон байснаа гуравдагч ертөнцийн орон”<sup>2</sup> болон хувирчээ.

Нэг хүнд ногдох Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 1989 онд 1,645 ам.доллар байсан бол 2003 онд 393 ам.доллар болтлоо огцом буурсан байна.<sup>3</sup>

Өнөө үед ч гэсэн Монгол Улс 1990 оны эхээр эхлүүлсэн ардчилал, минималист, чөлөөт эдийн засгийн тогтолцоонд шилжсэн улс төр болон эдийн засгийн шинэчлэлээ бэхжүүлж байна. Гэвч эдийн засгийн чөлөөт зах зээлд гэнэт шилжсэн нь ядуурлын туйл болон баян хоосны ялгааг бий болгосон. Дотоод дахь үйлдвэрлэл зогссоноор Монголын эдийн засаг нь үйлчилгээ, уул уурхай (нэн ялангуяа алт, зэс) болон хөдөө аж ахуй (тэр дундаа ноолуур)–гаас хараат байх болов. Гэсэн ч хөдөө аж ахуй нь уур амьсгалын хүчин зүйлс болох ган, цөлжилт болон хахир хүйтэн өвлөөс ихээхэн хамааралтай байдаг. Өнөө үед Монгол Улс нь Азид хөгжлийн түвшингээр нэн буурай хөгжилтэй орнуудын нэг болж байна. Нөгөөтэйгүүр, Монголын эдийн засгийг хөдөлгөх хүч гарч ирсэн ч үүнээс гарах ашиг тус, үр өгөөж нь хүнсний гачигдалтай, ядуу хоосон амьдарч буй нэгэнд хараахан хүрч очоогүй бололтой. Хэдийгээр Монгол Улс нь олон улсын тусламж дэмжлэгийг хамгийн ихээр хүлээн авч, хүнсний баталгаагүй байдал болон байнгын хоол тэжээлийн дутагдалтай байгаа асуудлыг Засгийн газар болон олон улсын агентлагууд шийдвэрлэхээр хүч чармайлт гаргаж байгаа ч, ядуурал ихсэхийн хэрээр дээрх асуудлууд хэвээр байсаар байна.

---

<sup>2</sup> О.Бруун, П.Роннаст, Л.Нарангоо, “Монгол Улс, Социалист төрөөс гуравдагч ертөнцөд шилжсэн нь,” Стокгольм, Сида, 2000 он

<sup>3</sup> “Монгол Улс дахь эдийн засгийн эмзэг байдал ба хүний аюулгүй байдал” Эдийн засаг, Нийгмийн асуудал хариуцсан албан томилолтын тайлан (2004 оны 6–р сар) 15 дахь тал.

## I. МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНСНИЙ ГАЧИГДАЛ, ХҮНСНИЙ БАТАЛГААГҮЙ БАЙДАЛ

### A. Хахир хүйтэн өвөл хийгээд зуд

6. 1999–2001 оны хооронд, Монгол Улс тэсгэм хүйтэн, зудтай хоёр өвлийг өнгөрөөсөн юм. Энэ нь хагас нүүдэлчин хэлбэрээр амь зууж, бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг малчдын хувьд маш хүндээр туссан билээ. Өнгөрсөн зуны ган, царцааны нүүдлээс болж тарга тэвээрэг муу авсан мал хахир хүйтэн өвлийн хүнд хучилттай цас, мөснөөс болж өвс тэжээлээ олж идэж чадахгүйд хүрч, өлсгөлөнгөөс болж турж үхэв. 2000 он гэхэд 3.5 сая гаруй тоо толгой мал хорогдсон бол 2001 онд 4.7 сая тоо толгой мал хорогдов.<sup>4</sup> 10,000 гаруй малчид ямар ч малгүй хоцорч, мянга гаруй айл өрх ихэнх малаа алдсан байна.

7. Хэдийгээр зуднаас болж мал сая саяар хорогдсон ч, малчдад хүнсний тусламж болон малын тэжээлийн тусламж үзүүлсэний ачаар хүнсний хомсдолд ороогүй. 2001 онд хийсэн судалгаагаар, зуданд нэрвэгдсэн аймагт амьдарч буй 5–аас доош насны хүүхдүүдийн хоол тэжээлийн дутагдалтай байдлыг зуданд нэрвэгдээгүй аймгийн хүүхдүүдтэй харьцуулахад гоц гойд ялгаа байхгүй байлаа.<sup>5</sup>

2003 онд хийсэн өөр нэг судалгаагаар зуданд нэрвэгдсэн орон нутагт 5–аас доош насны оюуны хомсдолтой хүүхдүүдийн тоо харьцангуй өндөр байсан ч (38 хувийг харьцах нь 26 хувь) энэ нь зуднаас бус харин өөр хүчин зүйлтэй холбоотой байж болох юм гэсэн дүгнэлт гарсан юм.<sup>6</sup>

Гэсэн ч уг судалгаагаар зудаас үүдэх урт хугацааны хоол тэжээлийн үр нөлөөний асуудлыг анхаарч авч үзсэн ч, нэн ядуурал болон амьжиргааныг эх үүсвэрээ алдах нь байнгын хоол тэжээлийн дутагдалтай тулгардаг болохыг үзүүлэлтүүдээр харуулсан байна.

8. 1990 оны эхээр хотод ядуурал хурдацтайгаар өсөхөд, олон айл өрх гэр энэ байдлаас ангид байх гэж хөдөө орон нутаг руугаа буцаж шилжин, бэлчээр газартаа эргэн ирсэн гэдгийг ойлгох нь чухал билээ. Эдийн засгийн уналт үргэлжилж, эдийн засгийн огцом шилжилтийн үед улсын үйлдвэрүүд татан буугдахад олон мянган хүн хотод ажилгүй болж, ихэнх хүмүүст мал маллах нь тэдний хувьд ганцхан сонголт болж үлдсэн. 1990–1999 оны хооронд малчдын тоо огцом өссөн бөгөөд 147,508 малчнаас 417,743 хүртлээ огцом өссөн байна (арваадхан жилийн дотор 183 хувиар өссөн). 1989–1998 оны хооронд хотын хүн амын тоо 13 хувиар буурсан байна.<sup>7</sup>

<sup>4</sup> Монгол Улсын Засгийн газрын Эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах стратеги, 2003 он, 2 дахь тал

<sup>5</sup> Эрүүл мэндийн яамны харьяа Хоол судлалын төв, ДЭМБ, ЮНИСЕФ, АНУ–ын Халдварт өвчний хяналт, урьдчилан сэргийлэх төвийн явуулсан Монгол Улс дахь зудаас үүдсэн хүнс тэжээлийн шинжтэй үр дагаварыг үнэлэх судалгааны (2001 он) урьдчилсан тайлан

<sup>6</sup> Монгол Улс дахь зудаас үүдсэн хүнс тэжээлийн шинжтэй үр дагаврыг үнэлэх судалгааны (2001 он) эцсийн тайлан, (өмнөх зүүлтийг үзнэ үү)

<sup>7</sup> Монгол дахь ядуурлыг бууруулах нь (Австралийн Үндэсний Их Сургуулийн Ази Номхон далайн хэвлэлийн газар, 2003 он) К.Гриффины “Хотоос хөдөөг чиглэсэн шилжилт нүүдэл ба мал аж ахуйн салбар дах тулгарсан асуудал” 57 дахь тал

Гэсэн ч мал маллах, бэлчээрийн аж ахуйд тулгарах хүнд хэцүү үе, эрсдэлд шинээр малчин болсон малчид болон хөдөө нутагтаа эргэн ирсэн малчид бэлтгэлээ сайн хангаагүй нь харагдсан. Тэд усны нөөц зэрэгт анхаарлаа хандуулж, сум, аймгийн төвүүдээр малаа бэлчээрлүүлэх болсон нь бэлчээрийн хомсдолд оруулж, газрыг үржил шимгүй болгосон. Зудны үеэр их хэмжээний малаа алдах нь малчдын амьжиргааны түвшинг улам ч дордуулж, ихэнх малчид хот руу буцахаас өөр аргагүйд хүрэв. 1995–2000 оны хооронд Улаанбаатар хот руу 75,000 хүн хөдөө орон нутгаас шилжин суурьшсан байна.

9. Гэвч малчдын дулимаг туршлага, бэлчээрийн хомсдол нь малчдын амьжиргааны тогтвортой эх үүсвэрт нөлөөлсөн ганц хүчин зүйл байгаагүй юм. Учир нь төрөөс хөдөө аж ахуйн салбарт анхаарал хандуулахаа больж, хөдөө орон нутагт хийх хөрөнгө оруулалт үгүй болсон буюу өмнө нь төрөөс хангаж байсан малчдын хэрэгцээ болох өвөлжөөний хашаа, яаралтай үед хэрэглэх малын тэжээл, усны худаг гаргах үйлчилгээ болон мал эмнэлгийн үзлэг үйлчилгээ үгүй болсноор цаг агаараас үүдэлтэй гамшигийг даван туулахад малчдыг улам ч сул дорой болгож байна. Хөдөөгийн дэд бүтэц уналтанд орсонтой зэрэгцэн мал аж ахуй дан ганц бэлчээр дээр тулгуурлах болсон. Мал аж ахуйн хоршоолол болох нэгдэл татан буугдаж, нийтийн удирдлагатай ямар ч бүтэц байгуулагдаагүй байна. Усны худаг, малын хашаа болон шаардлагатай үед хэрэглэх малын тэжээлийн нөөцийг хангах төрийн үүрэг үгүй болж, гагцхүү малчин хүн хувиараа энэ бүхнийг хийх болов. Одоогийн байдлаар, социализмын үед байгуулсан 35,000 гүний усны байгууламжийн 60 орчим хувь нь ажиллагаагүй байна.<sup>8</sup>

Энэ бүх үйлчилгээг дан ганц малчин хүн эрхлэн явуулна гэдэг амаргүй зүйл билээ. Хөдөө орон нутагт нийгмийн үйлчилгээний хүртээмж багассан явдал нь малчид ундны ус, сургууль соёл, эмнэлгийн төв, худалдаа үйлчилгээ болон мал эмнэлгийн үзлэг үйлчилгээнд илүү ойр байх хүн ам төвлөрсөн төв газар бараадан суурьшихыг илүүд үзэх болов. Гэвч хүн ам төвлөрсөн газраар суурьших нь газрын үржил шимийг үгүй болгож, бэлчээрийн хомсдолыг бий болгож байна. Бэлчээрийн хомсдолоос урьдчилан сэргийлэх байдлаар нүүдэллэх үндэсний ямар нэг хэв маягийг дахин бий болгоогүй байна. Хувийн мал эмнэлэг үзлэг үйлчилгээний хөлс авдаг болсноор малчдын малаа үзлэгт хамруулах явдал багасч, энэ нь малыг сул дорой, зуданд өртөмтгий болгож байна. Эдгээр өөрчлөлт нь Монголын хахир хүйтэн өвөл, халуун хуурай зунд малчдад илүү хүндрэл бэрхшээлийг авчирч байна.

## **В. Монгол Улс дахь хүнсний гачигдал, хүнсний баталгаагүй байдлыг эргэн харах нь**

10. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын мэдээлснээр, Монгол Улс нь Камбожаас гадна хүнсний баталгаагүй орноор Азид хамгийн дээгүүрт ордог байна. Хүн амын гуравны нэгээс илүү хувь нь хоол тэжээлийн дутагдалтай, Монгол хүмүүсийн 38 хувь нь өдөр бүр өөрсдийгөө болон гэр бүлээ хангалттай хоол хүнсээр хангах чадваргүй байна.<sup>9</sup>

<sup>8</sup> Мөн тэнд К.Грифин “Ядуурлын макро эдийн засаг” 15 дахь тал

<sup>9</sup> НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Дэлхий дээрх хүнсний баталгаагүй нөхцөл, байдал, 1 дүгээр хүснэгт

НҮБХХ–ийн Хүний хөгжлийн статистикт дурдсанаар 1990–ээс 2000 оны хооронд хүн амын хоол тэжээлийн дутагдалтай байдал 34 хувиас 38 хувь хүртэл өссөн байна. Монгол Улс нь хоол тэжээлийн дутагдалтай байдлаараа Кени болон Мадагаскар зэрэг Африкийн дэд Сахарын улсуудтай ижил түвшинд байна. Нэг хүнд ногдох өдрийн хоол тэжээлийн илчлэг нь ядуу гэр бүлийн хувьд өдөрт 1,784 килокалори бөгөөд энэ нь олон улсын стандарт түвшин болох 2,100 килокалори илчлэг болон Монгол хүний стандарт түвшин болох 2,731 килокалориас маш доогуур байна.<sup>10</sup>

Мянганы хөгжлийн зорилтын үндэсний илтгэлийн тооцоолон гаргаснаар хүн амын 20 хувийг эзлэх ядуу иргэд өөрсдийн олсон бүх орлогоо хоол хүнсэнд зориулсан ч зохистой хоол хүнс худалдан авах хангалттай орлого байхгүй байна. Уг илтгэлд дурдсанаар, ихэнх хүн өөрийн хэрэгцээт хүнс тэжээлийн зөвхөн гуравны хоёрыг л авдаг бөгөөд энэхүү хүнсний хэрэгцээ нь өвлийн цагт 30 хувиар буурдаг байна. Учир нь өвлийн цагт монголчууд хүйтний улирлыг тэсч гарахын тулд халаалтын түлшинд мөнгө зарцуулах хэрэгтэй болдог.<sup>11</sup> Монгол таван хүүхдийн нэг нь оюуны хомсдолтой ба 6.4 хувь нь жингийн дутагдалтай байна.<sup>12</sup>

1992–1999 оны хооронд жингийн дутагдалтай нярайн төрөлт 6 хувиас 10 хувь хүртэл болж өссөн бөгөөд нярайн эндэгдэл өндөр хэвээр байна.<sup>13</sup> Нийт хүүхдийн 13–аас илүү хувь нь хоол тэжээлийн хомсдол болон бусад өвчнөөс болж 5 нас хүрэхээс өмнө эндэж байна.

11. Бичил шим тэжээлт бодисын дутагдал ихэсч байна. Тухайлбал дөрвөн хүүхэд тутмын нэг нь төмрийн дутагдалтай байхад долоон хүүхэд тутмын нэг нь иодын дутагдалтай байна. Цус багадаа өвчин ихэсч, яс зөөлрөх өвчин буюу рахит тулгамдсан асуудал хэвээр байсаар байна.<sup>14</sup> Ундны цэвэр усны хүртээмжтэй байдал харилцан адилгүй бөгөөд хүн амын 40 орчим хувь нь сайжруулсан ундны усаар хангагдаж чадахгүй байна. Орон сууцанд амьдарч буй иргэдийг бодвол гэр хорооллын оршин суугчид цэвэр ус авахад бэрхшээлтэй тулгардаг бөгөөд илүү мөнгө төлдөг байна.<sup>15</sup> Ядуу гэр бүлүүд орлогынхоо 70 гаруй хувийг хоол хүнсэнд<sup>16</sup> зориулж, түүгээр ч барахгүй хоол хүнс, ундны ус, эрүүл мэнд, боловсрол болон өвлийн халаалтын түлшийн алинд нь мөнгөө зарцуулах вэ гэдэг хэцүү сонголттой тулгарч байна. Эдийн засгийн шилжилт нь эмэгтэйчүүдэд харьцангуй тэнцвэрт бус нөлөөлөл үзүүлж байна. Учир нь хувьчлал бий болсоноор, таван хошуу мал, үл хөдлөх хөрөнгө зэрэг ихэнх өмч хөрөнгийг гэрийн эзэн болох эрчүүдийн нэр дээр бүртгүүлэх болж, эмэгтэйчүүд эдгээр өмчийг захиран зарцуулах ямар ч эрх мэдэлгүй хоцорсон билээ.<sup>17</sup>

<sup>10</sup> Хүн амын хүнсний хэрэглээнд авах арга хэмжээний зөвлөмж, 1997

<sup>11</sup> Монгол Улс дахь Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн талаарх Үндэсний илтгэл, 2004 он 14–15 дахь тал. [http://www.nso.mn/mdg/eng\\_index.htm](http://www.nso.mn/mdg/eng_index.htm)

<sup>12</sup> Монгол Улсын Засгийн газар, Хоол тэжээлийн үндэсний судалгаа III, 2004 он

<sup>13</sup> Монгол Улсын Засгийн газар, Хоол тэжээлийн үндэсний судалгаа, 1999 он

<sup>14</sup> 11 дүгээр зүүлтийг үзнэ үү

<sup>15</sup> НҮБ–ын Хөгжлийн Хөтөлбөр, Монгол Улсын Хүний хөгжлийн илтгэл, 2003 он, 28 дахь тал.

<sup>16</sup> Монгол Улсын Засгийн газрын Эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах стратеги (3–р зүүлтийг үзнэ үү) 14 дэх тал

<sup>17</sup> Мөн тэнд 16 дахь тал

Хувьчлагдсан өмч хөрөнгийн 90 орчим хувийг нөхрийн нэр дээр бүртгүүлсэн гэсэн барагцаалсан тоо баримт гарсан байна. Хөдөө орон нутаг дахь эрүүл мэнд, боловсролын төв хаагдсан нь эмэгтэйчүүдэд бүр ч ноцтойгоор нөлөөлөх болов. Учир нь ажилгүйдэл, ядуурал, хүнсний гачигдал ихсэхийн хэрээр тэд гэр бүлийн хүчирхийлэлд илүүтэйгээр өртөх болов.<sup>18</sup>

12. Хэдийгээр Монголын хуурай халуун, богино зуны улирал, хахир хүйтэн, урт өвлийн улиралд ургац хураахад төдийлөн тохиромжтой бус ч, эрчимт үйл ажиллагаатай Зөвлөлт системийн дор улсын усжуулалт бүхий газар тариалангийн аж ахуйтай байхад Монгол Улс үр тариан үйлдвэрлэлээр дотоод хэрэгцээгээ бүрэн хангаад зогсохгүй овьёос экспортолж байсан байна. Гэвч 1990 оны эхэнд бий болсон эдийн засгийн гэнэтийн шилжилт нь хоол хүнсний хангалттай болон хүртээмжтэй байдлыг огцом бууруулахад хүргэсэн билээ. Улсын аж ахуйг татан буулгаснаар 1990 оноос 2003 оны хооронд хоол хүнсний үйлдвэрлэл 75 хувиар буурч, Монгол Улс хүнс-экспортлодог байснаа хүнс-импортлодог улс болон хувирсан байна.

Мөн энэ үед улсын мэдлийн үйлдвэрүүд татан буугдаж, ажилгүйдэл ихээр бий болсны улмаас нэн ядуурал хурдацтайгаар өссөн юм. Үндэсний статистикийн газрын мэдээгээр 1991 онд монгол нэг хүнд ногдох хоол тэжээлийн илчлэгийн дундаж хэмжээ олон улсын хамгийн бага түвшин болох 2,100 килокалориас багасч огцом буурсан байна. Өнөөдрийн байдлаар, илчлэгийн дундаж хэмжээ олон улсын түвшингээс (энэ нь Монгол Улсын илчлэгийн хэмжээ болох 2,731 килокалориас доогуур ч) буцаад дээшилсэн ч энэхүү дундаж үзүүлэлт нь хоол тэжээлийн дутагдал болон илүүдлийн хэмжээг бүрэн илэрхийлэхгүй байна.<sup>19</sup>

Засгийн газрын статистик тоо баримтаар хоол тэжээлийн дутагдлын цар хүрээний хувьд хөдөө орон нутгаас хотжисон газруудад илүү асуудалтай байна. 1999 оны Үндэсний хоол тэжээлийн судалгаагаар хөдөө орон нутаг дахь ядуу гэр бүлүүд шаардагдах хамгийн бага хүнсний хэрэглээнээс 58 хувиар бага хүнс тэжээл хэрэглэдэг гэж гарсан байна. Харин хотжисон газруудад амьдрах ядуу гэр бүлүүд хамгийн бага шаардагдах хүнс тэжээлийн хэмжээнээс 68 хувиар бага хүнс тэжээл хэрэглэдэг гэж судалгаагаар гарчээ. Нөгөөтэйгүүр, эдийн засгийн хувьд бололцоотой айлууд дээр дурдсан шаардлагатай хүнс тэжээлээс хавьгүй илүү илчлэг хүнс тэжээл хэрэглэдэг байна.

13. Монголын уламжлалт хооллолтын хэв маяг нь мал маллах хагас нүүдлийн амьдралын хэв маягт тулгуурлаж, ихэвчлэн мах болон цагаан идээнээс бүрдэнэ. Энэхүү хооллолт нь өөх тос ихтэй, харин нүүрс ус болон хүнсний ногоогоор бага юм. Суурьшмал амьдралын хэв маяг өсөн нэмэгдэж буй өнөө үед, ийм төрлийн хооллолт нь өндөр орлоготой буюу чинээлэг амьдралтай хүмүүсийн дунд зүрх судасны өвчин ихээр гарах шалтгаан болсон. Гэсэн ч ядуусын дунд хооллолтын өөр хэв маягийг бий болгож байна. Тухайлбал мах худалдан авах чадваргүй ихэнх ядуус оронд нь талх эсвэл гурилан бүтээгдэхүүн хэрэглэж голоо зогоож байна.<sup>20</sup>

<sup>18</sup> “Гэр бүлийн хүчирхийлэл, түүний эрүүл мэндийн үр дагавар” ЭМЯ-ны Эрүүл мэндийн газар, ЮНИСЕФ-ийн явуулсан эрдэм шинжилгээний судалгаа, 2004 он

<sup>19</sup> Монгол Улсын Засгийн газрын Эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах стратеги (3 дугаар зүүлтийг үзнэ үү) 10 дахь тал

<sup>20</sup> Дэлхий банк, Монгол Улс, Амьжиргааны стандартыг үнэлэх оролцооны үнэлгээ 2000 он.

Улаанбаатар хотын захын дүүргүүдэд амьдарч буй хүүхдүүдийн дунд хийсэн НҮБ-ын Хүүхдийн сангийн судалгаагаар ихэнх айлууд өдөрт ганц удаа хоол идэж аргацаадаг бөгөөд заримдаа сард хоёр гурван өдөр ч хоолгүй явах тохиолдол байдаг байна. Ихэнх хүүхдүүд хангалттай хоол тэжээлээр хангагдаж чадахгүй асуудалтай тулгарч байна.<sup>21</sup>

Гэр хороололд шинээр шилжин суурьшсан ихэнх айл албан ёсоор бүртгүүлээгүй учир гэр хороолол дахь ядуурлын албан ёсны статистик тоо баримт дутуу гарахад хүргэж байна.<sup>22</sup>

Дэлхийн банкны мэдээлснээр зарим хүн аргагүйн эрхэнд хог ухаж, хогийн үлдэгдлээр хооллох, түүнчлэн гэр бүлээ тэжээлийн тулд хулгай хийхээс өөр аргагүйд хүрч байна. Энэ нь Улаанбаатар дахь гэмт хэргийн тоог мөн нэмэгдүүлж байна.<sup>23</sup>

14. Хэдийгээр Монгол Улс хоол тэжээлийн дутагдал, хүнсний гачигдалтай байгаа нь ил тод, хоол тэжээлийн дутагдалтай байдлаараа Азид хамгийн ноцтой асуудалтай орны тоонд ордог ч, Тусгай илтгэгч Монгол Улс дахь хүнсний баталгаагүй байдлын талаар бүрэн цогц судалгаа хийгдээгүй болохыг олж мэдлээ.

Хэдийгээр хоол тэжээлийн талаар хэд хэдэн судалгаа хийгдсэн ч, эдгээр судалгаа нь хоол тэжээлийн ноцтой хомсдолын<sup>24</sup> байдлыг тодорхойлоход хангалтгүй бөгөөд хоол тэжээлийн дутагдлын талаар нарийн нягт мэдээлэл гараагүй байна. Тусгай илтгэгчийн үзсэнээр хүнсний баталгаагүй байдал болон хоол хүнсний дутагдалтай байдлын түвшинг тодорхойлох тогтсон хэмжигдэхүүн Монгол Улсад байхгүй байна.

Түүнтэй уулзаж ярилцсан холбогдох хүмүүс, ялангуяа олон талт хөгжлийн банкны албан хаагчид Монгол Улс хоол тэжээлийн дутагдалтай байгаа гэдэгт эргэлзэж, статистик тоо баримт уг мэдээг хэтрүүлж гаргасан байх гэж үзэж байлаа. Гэсэн ч хоол тэжээлийн дутагдалтай байдлын талаар янз бүрийн мэдээ баримтыг цуглуулж, хүнс тэжээлийн дутагдал болон ядуурлын статистик баримт мэдээг үзэхэд Монгол Улс хүнсний баталгаагүй байдал болон байнгын хоол тэжээлийн дутагдалтай байгаа юм байна гэж харагдсан. Иймд эдгээр асуудлыг нэн даруй авч хэлэлцэх шаардлагатай юм.

Мянганы хөгжлийн зорилттой холбогдуулан гаргасан илтгэлдээ Монгол Улсын Засгийн газар ийм асуудал байгааг хүлээн зөвшөөрсөн бөгөөд ядуурлын түвшний статистик тоо баримтаас хоол тэжээлийн хомсдол байгаа талаар тооцоог мөн харж болно. Засгийн газрын статистик мэдээгээр, Монгол Улсын нийт хүн амын 35.6 хувь нь ядуу бөгөөд тэд хангалттай хоол хүнс худалдан авах чадваргүйн улмаас хүнсний хомсдолын асуудалтай тулгарч байна.<sup>25</sup>

<sup>21</sup> “Улаанбаатар орчмын захын дүүргүүдийн хүүхдүүдийн амьдрах орчин” ЮНИСЕФ, ИБУИНВУ-ын Хүүхдийг ивээх сан, Хүүхдийн төлөө үндэсний төвийн хамтарсан судалгаа, 2003 он, 14 дэх тал.

<sup>22</sup> Мөн тэнд 11 дэх тал.

<sup>23</sup> Дэлхийн банк, өмнө нь эш татсан, (19 дэх зүүлтийг үзнэ үү)

<sup>24</sup> Үүнийг Колорадогийн Их Сургуулийн Хүн судлал, Эрүүл мэнд, Зан суртахууны Шинжлэх ухааны тэнхимийн Шарон Девайн “Хүнс тэжээлийн дутагдлаас тэр дундаа тэжээлийн бичил элементийн дутагдлаас болж Монгол Улсад учирч байгаа амьжиргаа, бүтээмжийн өртгийг тооцож болно. Гэхдээ үүний тулд байгууллагууд тодорхой мэдээлэл цуглуулж, судлаачидтай солилцох шаардлагатай” гэж үнэлсэн байна.

<sup>25</sup> Гриффиний эмхэтгэл дээрх (6 дугаар зүүлтийг үзнэ үү) Монгол дахь үндэсний ядуурлын шугамыг тодорхойлох арга зүйг М.Д.Бреннер “Монгол дахь ядуурал” гэсэн сэдэвт хөндсөн. 30 дахь талаас эхлээд ялангуяа 35 дахь талд.

Тусгай илтгэгчийн айлчлалын дүгнэлт гарснаас зургаан сарын дараа тэрбээр Монгол Улсын Засгийн газраас мэдээ хүлээн авсан бөгөөд 2004 онд хийгдсэн Үндэсний хоол тэжээлийн III судалгааны дагуу хоол тэжээлийн ноцтой дутагдалд орсон 5-аас доош насны хүүхдүүдийн тоо 1999 онд 2.86 хувь байсан бол 2004 онд 0.7 хувь болж буурсан гэсэн үзүүлэлт гарчээ. Тусгай илтгэгч энэхүү үзүүлэлтийг өөр бусад газраас тухайлбал НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага болон НҮБ-ын Хүүхдийн сангаас гаргасан баримт мэдээтэй шалгаж үзэх боломж байсангүй.

15. Амьдрах стандарт хэм хэмжээний 1998 оны судалгааны дагуу, ядуурлын түвшин хөдөө орон нутгаас (32 хувь) хотжисон газруудад (39 хувь) илүү өндөр байна. Монголын нийт хүн амын ойролцоогоор 57 хувь нь хот суурин газар амьдардаг ба байнгын ажилгүйдэл, бага цалинтайн улмаас Улаанбаатар хотын захын гэр хороололд болон аймаг, сумын төвд амьдрах хүмүүс мөн ядуу тарчиг амьдарч байна. Ажлын байрны баталгаагүй байдал нь хүнсний баталгаагүй байдлыг нэмэгдүүлж байна. Ажиллах хүчний дөнгөж 4.6 хувь нь ажилгүй гэсэн албан ёсны тоо баримт байгаа ч, бусад өөр барагцаалсан судалгаагаар энэ үзүүлэлт нь хамгийн багадаа 15 хувь, хамгийн ихдээ 48 хувь гэж гарч байна.<sup>26</sup>

Ядуусын ихэнх нь хотод албан бус салбарт бага хэмжээний худалдаа, үйлчилгээ эрхлэн гол зогоох төдий амь зууж байна. Зарим нь алт ухахаар явж, Төв аймагт алтны уурхайд хүнд хэцүү нөхцөлд ажиллаж амьдарч байна. Ядуусын ихэнх нь гэрт амьдарч буй<sup>27</sup> хөгшчүүлийнхээ авдаг шалихгүй тэтгэвэр тэтгэмжээс ихээхэн хамаарч, одоо өөрчлөгдөх гэж буй нийгмийн халамж, тэтгэврийн тогтолцооны шинэчлэл ч тэдэнд сөргөөр нөлөөлж болох юм.

Улаанбаатар хотод хийсэн сүүлийн үеийн судалгаагаар, 60<sup>28</sup> гарсан хүмүүсийн дунд ядуурлын түвшин хамгийн бага байсан бөгөөд магадгүй тэд тэтгэвэр тэтгэмж авдаг учир ийм үзүүлэлт гарсан байх. Хотод шинээр шилжин суурьшигчдын дунд ядуурлын түвшин өндөр байдаг байна. Хэрэв тэд шилжин суурьшсан талаар иргэний бүртгэлд бүртгүүлээгүй бол нийгмийн халамж үйлчилгээг хүртэх боломжгүй болдог байна. Өөр нэг судалгаагаар, шинээр шилжин суурьшсан айлын гурван хүний нэг нь ажилгүй бөгөөд сүүлд шилжин суурьшигчдын бараг 35 хувь нь хангалттай идэх хоолгүй ба “гурван гэр бүлийн нэг нь гэртээ идэх хүрэлцээтэй хоол хүнс байхгүй” гэсэн судалгаа гарсан байна.<sup>29</sup>

16. Нийт хүн амын 43 хувь нь хөдөө орон нутагт амьдарч байгаа бөгөөд тэдний зарим нь тэтгэвэр тэтгэмжээрээ амь зууж байгаа ч ихэнх орлогоо малынхаа ашиг шимээс хүртэж байна. Хөдөөгийн малчид малаасаа хоол хүнсээ авч, малаас гарсан бүтээгдэхүүнээс мөнгө олж байгаа ч нийт малчдын 55 орчим хувь нь 100 хүрэхгүй малтай бөгөөд энэ нь тогтвортой амьжиргаагаа залгуулахад хангалттай бус болж, тогтвортой

<sup>26</sup> Монгол Улсын Хүний хөгжлийн илтгэл, 2003 он, өмнө гарсан (14 дүгээр зүүлтийг үзнэ үү) 13 дахь тал, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамтай хийсэн хэлэлцүүлэгт гарсан мэдээлэл.

<sup>27</sup> Дэлхийн банк, (19 дүгээр зүйлийг үзнэ үү)

<sup>28</sup> Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Хүн амын боловсрол судалгааны төвийн хамтарсан “Хотын ядуурал, дотоодын шилжилт хөдөлгөөн” сэдэвт судагааны илтгэл (Улаанбаатар, 2004 он) 66, 71, 80 дахь тал.

<sup>29</sup> ДЭМБ, Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн газрын хамтарсан “Дотоодын шилжилт хөдөлгөөн, түүний нийтийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөө судалгааны тайлан” (Улаанбаатар хот, 2004 он), 26 дахь тал.

амьжиргааны хамгийн доод үзүүлэлт болж байна. Монгол Улсын алслагдсан газрууд, ялангуяа баруун аймагт амьдарч буй хүмүүс бага хэмжээний хөрөнгө оруулалт хүлээн авч байна. Зарим бүлгийн цөөнх, тухайлбал цаатангууд нийгмийн халамж үйлчилгээ хүртэх боломж байхгүйн дээр маш ядуу тарчиг нөхцөлд, хоол тэжээлээр дутмаг амьдарч байна. Зуны хуурайшил, ган, өвлийн хахир хүйтэн уур амьсгал гэх цаг агаарын тогтворгүй эрс тэс байдал нь хүнсний баталгаагүй байдлыг улам бүр нэмэгдүүлж, ядуурал нэмэгдэхийн хирээр хүмүүс сул дорой болж байна. Малаа олон тоо толгойгоор нь алдах хөдөөгийн хөгжилд хөрөнгө оруулалт хийгдэхгүй байх зэргээс үүдэн хөдөөгийн ихэнх айлууд амьдрахын эрхээр арай боломжтой айлд малыг нь хариулах зэргээр ажиллах, эсвэл ажил хайхаар хот уруу нүүж байна.

17. Тусгай илтгэгч хот болон хөдөө орон нутгийн хоёулангаар нь айлчилсан билээ. Улаанбаатарт тэрбээр гуанзны үлдэгдэл хоол, ядуусыг хооллох газрын хоолоор амь зогоож буй монголчуудтай уулзсан. Мөн тэрбээр газар доорх шугам сүлжээний хоолой болон муу усны сувгаас олдож, өнчин хүүхдийн асрамжийн газар хүргэгдсэн хүүхдүүдтэй уулзсан юм. Эдийн засгийн шилжилтээс хойш гудамжны тэнэмэл хүүхдүүдийн тоо эрс нэмэгдсэн байв. Учир нь энэ үед ажилгүйдэл, эдийн засгийн баталгаагүй байдал нь нийгэм болоод гэр бүлд уналт авчирсан юм.

Тэрбээр улсын асрамжийн газарт хоол тэжээлийн дутагдлаас болж алхаж ч, ярьж ч чадахгүй 6 настай хүүхэдтэй уулзсан бөгөөд бусад хүүхдүүд ч мөн адил биеийн болоод оюуны хомсдолтой байв. Тэрбээр Улаанбаатарын ядуусын дүүргүүдэд хүнсний баталгаагүй байдлын үзүүлэлт өндөр болохыг, мөн байнгын хоол тэжээлийн дутагдалтай байх явдлыг нүдээр үзсэн билээ.

Мөн тэрбээр хөдөө орон нутагт ядуурал газар авч, ялангуяа мал сүргээ алдсан малчдын хувьд ядуурах зовлон бий болоод буйг ажигласан юм. Тусгай илтгэгч Сэлэнгэ аймагт айлчилж хүн ардтай уулзаж байхдаа, газрын эзэд, газаргүй ажилчид болон хөлсөөр мал хариулагчдын хооронд нийгмийн шинэ анги үүсээд байгааг мэдэрсэн. Илүү хуурай өмнө зүгт орших Дундговь аймагт амьдрахад бүр ч хэцүү бэрх санагдсан. Учир нь малын бэлчээрийн газрыг сайжруулахад зориулах усны нөөцийн төхөөрөмжид хөрөнгө оруулалт хийгдээгүй байв.

18. Усны хүртээмжийн асуудал их ярвигтай бөгөөд маш харьцангуй байдаг. Эдийн засгийн шилжилтээс хойш усны чанар, ариун цэврийн үзүүлэлт муудсан гэж дүгнэдэг. Улаанбаатар хотын нийт хүн амын 55 хувь нь (голдуу гэр хорооллын оршин суугчид) усны төвийн нэгдсэн сүлжээнд холбогдох боломжгүй буюу илүү үнэтэйгээр, усны машин аль эсвэл усны мухлагаас холоос очиж авдаг байна. Орон сууцанд оршин суугчдын усны өдрийн хэрэглээ нь 240–250 литр бол гэр хороололд амьдарч буй хүмүүсийн усны өдрийн хэрэглээ нь дөнгөж 8–10 литр байдаг байна.<sup>30</sup>

Жишээлбэл Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороонд амьдрах 10,000 гаруй оршин суугчдын хэрэглээг хангах усны худаг дөнгөж гуравхан байдаг байна. Усны хангамж нь хэрэглээнд хүрэлцдэггүй ба зарим тохиолдолд хүүхдүүд 2–3 цаг урт дараалалд зогсон байж эхний эгнээнд дөнгөж хүрч очиход ус аль хэдийн дууссан байдаг байна. Зуны цагт

<sup>30</sup> Монгол Улсын Хүний хөгжлийн илтгэл, 2003 он, өмнө гарсан (14 дүгээр зүүлтийг үзнэ үү) 31 дэх тал



гэр хорооллынхон голын ус, булаг шандны усыг хэрэглэдэг ч өвлийн улиралд голын ус хөлдөхөд өндөр үнэтэй ч гэсэн усны мухлагаас ус авахаас өөр сонголт байдаггүй байна. Мөн хувь хүн болон аж ахуйн нэгжийн хооронд, ялангуяа уул уурхайн компаниудын усны хэрэглээ харилцан адилгүй байна. Гэр хорооллын оршин суугчид уул уурхайн компаниудтай харьцуулахад усны хэрэглээндээ 84 дахин илүү мөнгө төлдөг болохыг НҮБХХ-ийнхэнтэй уулзаж ярилцаж байхад олж мэдлээ. Уул уурхайн үйл ажиллагаанаас болж мөнгөн усны асуудал гарч ирэх болж энэ нь гүний худаг шанд, булаг зэрэг усны нөөцийг бохирдуулж байгаа ноцтой асуудлыг хөндөж ярьсан. Үүнээс үзэхэд уул уурхайн үйл ажиллагаан дахь байгаль орчны зохицуулалт сул, байгаль орчны болоод нийгэмд гарах сөрөг үр дагаврыг тооцож үзэлгүйгээр зөвхөн эдийн засгийн өсөлтөнд анхаарлаа хандуулж байгаа нь харагдаж байна. Ус нь амьдралын амин чухал хэрэгцээ болоод зогсохгүй хоол хүнсээр хангагдах эрх, хоол тэжээлийн хувьд нэгээхэн чухал хэсэг болж байхад цэвэр усны хүртээмжийн асуудал улам бүр хэцүү болж байна.

## **II. МОНГОЛ УЛС ДАХЬ ХООЛ ХҮНСЭЭР ХАНГАГДАХ ЭРХ ХУУЛЬ ЗҮЙН ХҮРЭЭ**

### **A. Олон улсын өмнө хүлээсэн үүрэг хариуцлага**

19. Монгол Улс нь Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактыг соёрхон баталсан бөгөөд уг пактын 11 дүгээр зүйлд хоол хүнсээр хангагдах эрхийг тусгасан байдаг. Мөн зохистой хоол хүнсээр хангагдах эрх, зохистой хоол тэжээлээр хангагдах эрхийг тусгасан олон улсын нилээд олон гэрээ конвенцид нэгдэн оржээ. Тухайлбал Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (6 дугаар зүйл), Хүүхдийн эрхийн конвенц (24 болон 27 дугаар зүйл) болон Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (12 болон 14 дүгээр зүйл) тус тус орно. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахын эсрэг хороонд хүргүүлсэн илтгэлээс бусад эдгээр конвенцийн дагуу Монгол Улсын Засгийн газраас тогтмол хүргүүлэх бүх илтгэлийн хугацаа хэтэрсэн байна.

20. Хоол хүнсээр хангагдах эрхийн дагуу олон улсын өмнө хүлээсэн үүргийн дагуу Монгол Улс ард түмнийхээ хоол хүнсээр хангагдах эрхийг аливаа ялгаварлан гадуурхалтгүйгээр хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх үүрэгтэй билээ. Хүндэтгэх үүрэг гэдэг нь тухайн улс хүмүүсийн хоол хүнсээр хангагдах эрхийг дур зоргоороо хязгаарлах үйлдэл хийх ёсгүй гэсэн үг юм. Хамгаалах үүрэг гэдэг нь бусдын хоол хүнсээр хангагдах эрхийг зөрчиж болзошгүй гуравдагч этгээдээс урьдчилан сэргийлэх зорилгоор тухайн улс зохистой хууль тогтоомжийг бий болгож мөрдүүлэх шаардлагатай юм.

Хамгийн сүүлийнх буюу хэрэгжүүлэх (хөнгөлөлт үзүүлэх, хангах) үүрэг гэдэг нь тухайн улс эмзэг бүлгийг тодорхойлох зохистой арга хэмжээ авч, тэднийг өөрсдийгөө тэжээх чадварт тус дөхөм үзүүлж, зохистой хоол хүнс болон усаар хангах боломжтой зохистой бодлого, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх явдал юм. Эцсийн арга болгож өөрсдийгөө тэжээх чадваргүй болсон хүмүүсийг Засгийн газар зохистой хоол хүнс, ундны усаар хангах үүрэгтэй. Тухайн улс хоол хүнсээр хангагдах эрхийг хэрэгжүүлэхийн тулд

олон улсын хамтын ажиллагааны тусламж болон өөрийн дотоод хамаг нөөц бололцоогоо ашиглан, ямар ч тохиолдолд хүн ардаа өлсгөлөнгөөс ангид байлгахад шаардагдах хамгийн бага нөөц бололцоогоор хангаж байх үүрэгтэй. Хоол хүнсээр хангагдах эрхэд газар эзэмших боломж, ундны усны хүртээмжтэй байдал болон хэрэгцээгээ хангах, газар тариаланд шаардагдах усжуулалт орно. Оролцоо, хариуцлага болон нөхөн төлбөр авах боломж бүх цаг үед болон хоол хүнсээр хангагдах эрхийг хэрэгжүүлэх бүх түвшинд хангагдах ёстой.

### **В. Үндсэн хууль болон хууль тогтоомжийн хүрээ**

21. 1992 оны Монгол Улсын Үндсэн хууль ардчилал болон эдийн засаг, нийгмийн олон янзын эрхийг тусгасан хүний үндсэн эрх, эрх чөлөөг Монголын ард түмэнд баталгаажуулж өгсөн билээ. Уг Үндсэн хуульд хоол хүнсээр хангагдах эрхийг тусгайлан заагаагүй ч хамгийн эмзэг бүлэгт хоол хүнсний хүртээмжтэй байдлыг бий болгох болон уг эрхтэй хамааралтай олон зүйл заалтыг тусгасан байдаг.

22. 16 дугаар зүйлийн 5–д “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй” гэж заасан нь эдгээр бүлгийн хүмүүс тодорхой хэмжээний хамгаалалт авч, Засгийн газар хоол хүнсний тусламж үзүүлэх шаардлагатай болж байна. Хоол хүнсээр хангагдах эрх нь хөдөлмөрлөх эрх, зохистой амьжиргааны түвшинд байх эрх болон хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх эрхэд мөн хамааралтай.

Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлээр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх эрхийг баталгаажуулж өгсөн. 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт Монгол Улсын иргэн эрх, эрх чөлөөгөө хууль, шүүхээр хамгаалуулах эрхтэй, “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан” буюу “бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх” гэж заасан байдаг.

Эдийн засаг, нийгэм болон соёлын эрх гээд Үндсэн хуульд тусгагдсан бүх л эрхээ хэрэгжүүлэхэд шүүхээс тусламж хүсэх боломжтой гэдгийг тусгай илтгэгч олж мэдсэн байна. Хэдийгээр Үндсэн хуульд “Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй” (10 дугаар зүйл 4 дэх хэсэг) хэмээн зааж, дотоодын хууль тогтоомжоо олон улсын хуулиас дээгүүр тавьсан ч Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ гэж заасан байдаг. Аливаа зөрчил гаргахгүйн үүднээс (CCPR/C/79/Add.120, para. 7) хүний эрхийн тухай аливаа пакт нь дотоодын хууль тогтоомжоос дээгүүр байх ёстойг хуульд тодорхой зааж өгөх хэрэгтэй гэсэн Хүний эрхийн зөвлөлийн ажиглалт, дүгнэлттэй Тусгай илтгэгч санал нэг байна.

23. Монгол Улсын хууль эрх зүйн хүрээнд зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг хэрэгжүүлэхдээ шууд холбоотой бусад олон хууль тогтоомж болон зохицуулалт байдаг. Эдгээрээс хамгийн чухал нь 1995 онд батлагдаж, 1999 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан Хүнсний тухай хууль юм. Уг хуулийн зорилго нь хүн амын хүнсний хэрэгцээ, хүнсний баталгаат байдлыг хангах, мөн хүнсний бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотойгоор үүсэх Засгийн газар, хувь хүн болон хуулийн этгээдүүдийн харилцааг зохицуулахад оршино. Гэсэн ч хуулийн хамрах бодит хүрээ нь хуульд заасан зорилтоосоо явцуу байна. Уг хууль

нь голчлон хүнсний баталгаат байдлын хэм хэмжээ болон хүнсний хангамжид илүү анхаардаг. Уг хуулиар хүнсний тэжээллэг чанарыг хангах хэрэгтэй гэж заасан ч хүнсний хүртээмжийн болон бусад асуудал дээр ямар нэгэн арга хэмжээ авахыг тусгаагүй, тэр бүү хэл Монгол Улсын нутаг дэвсгэр дээр амьдарч буй бүх хүн хоол хүнсээр хангагдах эрхтэй гэдгийг ч тусгаагүй байна. Мөн уг хуулиар хариуцлагын ямар ч механизмыг бий болгоогүй байна.

24. Нийгмийн халамжийн тухай 1998 оны хуулиар “нэн ядуу” иргэд гэсэн тодорхойлолтыг гаргаж өгсөн. Ядуурлын түвшнээс 40 хувиар доогуур орлоготой, үүнээс үүдэн “хязгаарлагдмал хэрэглээ”-тэй хүнийг “нэн ядуу” гэж тодорхойлно гэж заасан. “Хязгаарлагдмал хэрэглээ” гэж хүнсний хязгаарлагдмал хэрэглээг хэлж байгаа байх. Гэсэн ч Хүний эрхийн Үндэсний Комиссын үзэж байгаагаар “хязгаарлагдмал хэрэглээ” гэдэг нь тодорхой бус ойлголтоос үүдэн уг нэр томъёог тодорхойлоогүй гэж үзэж байна.<sup>31</sup>

Нийгмийн халамжийн тухай хууль нь Нийгмийн даатгалын тухай хуулийг нөхөх чухал хууль бөгөөд Даатгалын тухай хуулиар хуулийн дагуу тэтгэвэр авах эрх олгогдоогүй хүмүүсийг хамруулж, тэднийг тодорхой хэмжээний орлоготой болгодог байна. Эдгээр хуулийн хамрах хүрээ нь хязгаарлагдмал мөн үүнийг хүртэх боломжтой хүмүүс тэр бүр энэ хуулийн тухай мэдэхгүй байх явдалд тусгай илтгэгч сэтгэл зовниж байна. Хөдөлмөрийн яамнаас Тусгай илтгэгчид хүргүүлсэн мэдээгээр уг хуулийн дагуу олгох мөнгөн тэтгэмж нь 14,400 төгрөг бөгөөд энэ нь амьдралд огт хүрэлцдэггүй байна. Учир нь Улаанбаатарт амьдрах хамгийн наад захын хэрэглээний өртөг нь 27,000 төгрөг юм.

25. Газар эзэмших болон газар ашиглах тухай хууль тогтоомж нь нэн ялангуяа хоол хүнсээр хангагдах эрхэд чухал үүрэгтэй. Хүн амын бараг тал хувь нь хөдөө аж ахуй, тэр дундаа мал аж ахуйгаас ихээхэн хамаарч амьдардаг. Монгол Улсын газрын тухай одоогийн хууль тогтоомжид 2000 болон 2002 оны хооронд нэлээдгүй өөрчлөлт оруулж шинэчилсэн. Энэ нь эдийн засгийн шинэчлэл болон чөлөөт зах зээл рүү чиглэх нэгээхэн алхам болж, хүнс, хөдөө аж ахуй ба уул уурхайн салбарт гадны хөрөнгө оруулалт хийх нөхцлийг сайжруулсан. Газрын тухай хууль болон Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль гэсэн хоёр чухал хуулийг 2002 онд баталсан. Эдгээр хуулиуд Монгол Улсын иргэдийн газар эзэмших эрхийг баталгаажуулж, хувьчлах явцад газар ашиглах дүрэм журмыг шинээр оруулж өгсөн.

26. Бэлчээрийн газрыг өмчлөх газарт оруулаагүй ч хот болон хөдөө орон нутагт бусад зориулалтаар ашиглах газрыг өмчилж болно. Одоогийн байдлаар нийт газар нутгийн 0.9 хувь нь хувьчлагдаад байна. Хотын төвийн газрыг иргэдэд үнэ төлбөргүй олгож байна. Нийслэл хотод амьдарч буй өрх гэрт 0.07 га, аймгийн төвд 0.35 га, сумын төвд харин 0.5 га газрыг тус тус олгоно. Хөдөө орон нутагт газар тариалангийн салбарт ажилласан өрх гэр, иргэдэд 100 хүртэлх га тариалангийн газар олгож болох ба харин ногоо тарихад (29.3 дугаар зүйл) 5 хүртэлх га газар тус тус олгохоор заасан. Газар тариалан эрхлэх үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжүүдэд олгох газрын хэмжээг аймгийн удирдлага шийднэ. Тухайлбал үр тариа болон малын тэжээлийн үр тарианд

---

<sup>31</sup> Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл (2003 он), 30–31 дэх тал

3,000 хүртэлх га, хүнсний ногоо тарихад 50 хүртэлх га болон худалдааны хадлан бэлтгэх зориулалтаар 1,500 хүртэлх га газрыг тус тус олгож болно.

Монгол Улсын нилээд олон аж ахуйн нэгж, хуулийн этгээд газар тариалангийн зориулалттай газар эзэмшдэг болохыг тусгай илтгэгчид мэдээлжээ. Энэ нь хувь хүн болон аж ахуйн нэгжийн хооронд газар хуваарилан олгох нь харилцан адилгүй, тэгш бус байна гэсэн асуудлыг хөндөж байна. Нэмж хэлэхэд, компани болон хувь хүнд газар ашиглуулах болон өмчлүүлэх эрхийн гэрчилгээ олгох үйл явцад авлига, хээл хахуулиас урьдчилан сэргийлэх ил тод байдлын болон хариуцлагын зохистой механизм төдийлөн байхгүйд Тусгай илтгэгч сэтгэл зовниж буйгаа илтгэж байна.

27. Хуулийн дагуу, бэлчээрийн газрыг гагцхүү хамтын эзэмшлээр ашиглаж болно. Газрын тухай хуулийн 54 дүгээр зүйлд бэлчээрийн газрыг хадгалах болон ашиглах тухай нутгийн удирдлагын үүрэг хариуцлагыг тодорхойлсон байдаг. Үндэсний бэлчээрийн газрыг хамгаалж, зөв зохистой ашиглах явдлыг хангахын тулд аймаг, сумын засаг дарга нар холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран газар ашиглах уламжлал, газрыг зөв зохистой ашиглах болон хамгаалах тухай шаардлагыг анхааран авч үзэж, газрын зөв зохицуулалтын талаар үйл ажиллагаа явуулах шаардлагатай.

Хөгжиж буй газрын болон хөдөө аж ахуйн зах зээлд хүчтэй бодлого хэрэгтэй, мөн олон нийт газар эзэмших явдлыг хамгаалах, ялангуяа малчин өрх гэрүүдийн амьжиргааг залгуулахад амин чухал бэлчээрийн газрыг хүртээмжтэй эзэмшүүлэх хэрэгтэй. Эдгээр бодлогын хооронд зохистой тэнцвэрийг нь хангах гэж хичээж буй Монгол Улсад Тусгай илтгэгч талархлаа илэрхийлж байна. Тэрбээр Монгол Улсын цаашдын чөлөөт зах зээл болон газар өмчлүүлэхийг яаравчлуулах гадаадын шахалт өсөн нэмэгдэж байгааг мэдэж байгаа бөгөөд хоол хүнсийг хүртээмжтэй болгох болон хүртээмжтэй хангах олон улсын хүний эрхийн хэм хэмжээгээр хүлээсэн үүргийг Засгийн газарт сануулж байна. Монгол Улсын хүн амын ихээхэн хэсгийг эзлэх хөдөө аж ахуй эрхлэгчид болон малчдад бэлчээрийн газрыг хүртээмжтэй болгох хэрэгтэй бөгөөд бусад хэрэглээний газар нь тэдний амьжиргаанд чухал үүрэг гүйцэтгэдэг билээ.

### **С. Байгууллагын хамрах хүрээ**

28. Хүний эрхийн Үндэсний Комиссыг 2000 онд байгуулахад Засгийн газраас идэвхийлэн оролцож, Хүний эрхийг хангах анхны үндэсний хөтөлбөрийг баталж гаргасан. Хэдийгээр уг хөтөлбөрийн хэрэгжилт сүүлд болсон сонгуулийн үеэр түр хойшлогдсон бөгөөд сонгуулийг хянах Хороо хараахан байгуулагдаагүй байсан нь тусгай илтгэгчийн анхаарлыг татсан билээ. Гэсэн ч Парисын зарчимтай нийцэж, улс төр, эдийн засаг болон эрх зүйн хувьд бие даасан бүтэцтэй Хүний эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК)-ын ажлыг тэрбээр сайшаасан юм.

29. Хүний эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК) нь хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих эрх бүхий байгууллага бөгөөд хүний эрхийн нөхцөл байдлын талаарх илтгэлээ жил бүр УИХ-д өргөн барьдаг. Комисс нь дотоодын хууль тогтоомж олон улсын хэм хэмжээтэй хэр нийцэж байгаад хяналт тавих үүрэгтэй. ХЭҮК нь Үндсэн хуулиар баталгаажуулсан эрх, эрх чөлөө болон Монгол Улсын нэгдэж орсон олон улсын гэрээ конвенцид тусгагдсан эрхийн зөрчлийн талаар хувь хүмүүсээс гомдол хүлээн авч болно.

Зохистой хоол хүнсээр хангагдах эрх нь эдийн засаг, нийгэм, соёлын эрхэд хамаарах бөгөөд үүнийг хэрэгжүүлэх нь Комиссын чиг үүргийн хүрээнд багтана. Өнөөг хүртэл Комисс иргэний эрх чөлөө болон захиргааны хэргийн шүүхийн тал дээр голлон ажиллаж байсан бол одооноос эхлэн ядуурал ба эдийн засаг, нийгэм, соёлын эрх дээр анхааран ажиллаж байна.

Комиссын 2002 оны илтгэлд эрүүл мэндээ хамгаалуулах эрх, сурч боловсрох эрх, нийгмийн халамж хүртэх эрх болон хөдөлмөрлөх эрхийн асуудлыг тусгасан бол 2003 оны илтгэлд дээр дурдсан эрхийг хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нэн ядуу иргэд гэх зорилтот бүлгийн хүмүүстэй холбоотой асуудлыг тусгасан билээ. Комисс одоогийн байдлаар хоол хүнсээр хангагдах эрхтэй холбоотой тусгайлсан ямар нэг хэрэг дээр ажиллаагүй байгаа ч ялгаварлан гадуурхалтын үндсэн дээр Улаанбаатар хотод шинээр шилжин суурьшигчдаас бүртгэлийн хураамж авдаг байсан хэргийг шүүхэд нэхэмжлэн улмаар ялсан билээ. Хэдийгээр бүртгэлийн үйл явц төвөгтэй хэвээр байгаа ч, албан ёсоор бүртгэлийн хураамж гэж авахгүй болсон нь ялангуяа ядуу хүмүүст нийгмийн халамж үйлчилгээг хүртэх боломжийг бий болгоход чухал ач холбогдолтой болсон.

30. Ерөнхийд нь авч үзвэл ядуу хүмүүст үйлчлэх хуулийн хүртээмж муу хэвээр байна. Хэдийгээр шүүх засаглал нь бие даасан байх учиртай ч хүний эрхийн асуудлаарх шүүгчдийн мэдлэг боловсрол хангалтгүй, ялангуяа эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн асуудал дээр дулимаг байна. Мөн шүүх тогтолцоонд хэлэлцэхээр товлосон хэргүүд болон авлигын хэргийн асуудал их байна. Шүүхэд хандах боломж нь алслагдмал байдал (хөдөө орон нутгаас ирвэл) болон шүүгч, өмгөөлөгч хөлслөх өндөр үнийн улмаас хүндрэлтэй байна.<sup>32</sup>

### III. ХООЛ ХҮНСЭЭР ХАНГАГДАХ ЭРХИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭ

#### А. Засгийн газрын бодлого болон холбогдох байгууллагууд

31. Монгол Улсад хүнсний хангамж, хүнсний аюулгүй байдал болон хоол тэжээлийн асуудлаарх бодлого, холбогдох байгууллагууд олон байдаг ч хоол хүнсний хүртээмжийн асуудалтай холбоотойгоор хүнсний аюулгүй байдлыг авч үзэх нэгдсэн стратегийн бодлого байхгүй мэт санагдсан. Хүний эрхэд суурилсан хандлагатай цөөн бодлого боловсруулсан ч хоол хүнсээр хангагдах эрхийн тухай ойлголтыг нэмэгдүүлэх асуудлыг нааштайгаар авч үзэхээ Засгийн газар илэрхийллээ.

32. Хүнсний баталгаат, аюулгүй байдал ба хоол тэжээлийн тухай үндэсний хөтөлбөрийг 2001 оны 10 дугаар сард баталсан нь хоол хүнсээр хангагдах эрхтэй холбоотой Засгийн газрын гол стратеги бөгөөд энэ асуудлыг Хүнс, хөдөө аж ахуйн яам эрхлэн хариуцна. Уг хөтөлбөр нь хүнсний хангамж, хүнсний аюулгүй байдал ба хоол тэжээлийн тухай гол асуудлыг тусгасан байдаг. Мөн уг хөтөлбөрт хүнсний хангамжийг сайжруулах стратеги төлөвлөгөө болон хүнсний ногоо, сүү, сүүн бүтээгдэхүүнийг

---

<sup>32</sup> НҮБ-аас Монгол Улсад үзүүлэх Хөгжлийн туслалцааны баримт бичиг, 2002–2006 он, Улаанбаатар хот, 2001 оны 6 дугаар сар, 12 дахь тал.

“Ногоон хувьсгал” болон “Цагаан хувьсгал” гэх мэт хөтөлбөрөөр дамжуулан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг хөхиүлэн дэмжих төлөвлөгөөнүүд оруулсан. Тусгай илтгэгч айлчлалынхаа үеэр олон аж ахуй, үйлдвэрийн газраар орж үр тарианы болон боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн ба сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дахин сэргээх гэсэн хүч чармайлтуудыг олж харсан билээ. Монгол Улс хүнсний бүтээгдэхүүнийхээ 70 гаруй хувийг импортлодог учир Хүнс, хөдөө аж ахуйн яам дотоодын хүнсний бүтээгдэхүүнээ нэмэгдүүлэхийг зорьж байна.<sup>33</sup>

Хүнсний тухай 1995 оны хуулийн дагуу Үндэсний хөтөлбөрт хүнсний аюулгүй байдлыг сайжруулах чухал стратегийг тусгасан ч худалдааг либералчлах болсноор гаднаас чанар муутай хүнсний бүтээгдэхүүн ихээр орж ирэх болсон гэж олон нийт санаа зовниж буй асуудлыг гаргаж ирсэн. Мөн Үндэсний хөтөлбөрт хүнсний тэжээллэг байдлыг сайжруулах стратеги төлөвлөгөөг тусгасан билээ. Тухайлбал боловсролоор дамжуулан хүнсний ногооны хэрэглээг дэмжих, мөн хүнсний ногооны бүтээгдэхүүн болон зарим гол хүнсэн дэх бичил шимт бодисыг сайжруулахыг хөхиүлэн дэмжих хэрэгтэй юм.

Хэдийгээр хөтөлбөрт хоол тэжээлийн хангалттай бус байдлын талаар дурдсан ч, харамсалтай нь байнгын хүнсний хомсдол болон нэн ядуурлын өөр хоорондын нөлөөллийг авч үзээгүй байна. Уг хөтөлбөрт хүнсний аюулгүй байдал гэдгийг хүнсний нөөц (хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээс гарах хүнсний хангамж) гэдгээр тодорхойлсон ба хүнсний хүртээмжийн асуудлыг дурдаагүй байна. Түүнчлэн Монгол Улс дахь хүнсний хомсдол болон хүнсний баталгаагүй байдлын шалтгааны тухай статистик тоо баримт болон дүгнэлтийг тусгаагүй байна. Хүнсний хүртээмжтэй байдал нь хоол хүнсээр хангагдах эрхийн гол тулгуур бөгөөд хүнсний аюулгүй байдлын асуудал хариуцах холбогдох яамдын үүрэг хариуцлага болон хүнсний аюулгүй байдлын тухай бүхий л хүчин зүйлийг гаргаж ирэх нэгдсэн стратегитай байх нь чухал юм.

33. Эрүүл мэндийн яам одоогоор тэжээлийн хомсдолын талаарх асуудал болон эмэгтэйчүүд, хүүхдүүд рүү чиглэх хэд хэдэн стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хариуцаж байгаа. Иодын дутагдлаас үүдэх цус багадаа өвчнийг бууруулахад чиглэсэн гурилан бүтээгдэхүүнийг сайжруулах төсөл ч хөтөлбөрүүдэд тусгагдсан байна. Тус яам “5–аас доош насны хүүхдүүдийг бичил шимт бодисын дутагдлаас урьдчилан сэргийлэх” төлөвлөгөөг боловсруулсан бөгөөд уг төлөвлөгөөгөөр хүүхдүүдийг А, Д амин дэм болон төмрийн бэлдмэлээр хангахад голлон анхаарч байна. Мөн Засгийн газрын зүгээс “Монгол Улс дахь хүүхдийн төлөө зорилтууд” төсөл боловсруулсан бөгөөд уг төслөөр 5–аас доош насны хүүхдийн эндэгдэл болон тэжээлийн хомсдолыг бууруулах, Д амин дэмийн нэмэлт бүтээгдэхүүний хэрэглээний хангамжийг нэмэгдүүлэх, хөхөөр хооллох явдлыг нэмэгдүүлэх болон орон даяар иодтой давс хэрэглэх явдлыг хангах зорилгыг тус тус дэвшүүлсэн юм.

Мөн Эрүүл мэндийн яам нь бусад яамтай хамтран эрүүл зөв хооллолт болон хүнсний аюулгүй байдлыг хөхиүлэн дэмжихийн тулд хүнсний тэжээллэг байдлын талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч байна. Эдгээр бодлого нь Монгол Улс

<sup>33</sup> “Монгол Улс дахь хүнсний баталгаагүй байдал,” Дэлхий зөнгөөс гаргасан баримт бичиг (2004 оны 8 дугаар сар), 7 дахь тал

дахь хүнсний тэжээлийн хомсдолд чиглэсэн чухал бодлогууд юм. Гэвч эдгээр бодлого нь хүнсний хэрэглээний хомсдол болон эх хүүхдэд нөлөөлөх тэжээлийн дутагдлын асуудлыг авч үзэлгүйгээр зөвхөн бичил шимт бодисыг нэмэлт бүтээгдэхүүнээр хэрэглэх, нэмэгдүүлэх явдлыг дэмжих тал дээр голлон анхаарч байна. Тусгай илтгэгч Эрүүл мэндийн яамны ажилтнуудтай уулзсан бөгөөд хоол хүнсний дутагдалтай байгаа асуудлыг ахлах мэргэжилтнүүд мэдэж байгаа ч энэ нь тэдний эрх мэдлийн хүрээнээс гадуур асуудал мэт санагдсан билээ.

34. Монгол Улс дахь хүний хөгжилд хяналт тавих, ядуурлыг бууруулах Засгийн газрын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх нь Нийгмийн халамж, хөдөлмөрийн яамны үүрэг болно. Яам нь тэтгэвэр тэтгэмж, албан салбарт буй ажилгүйдлийн хангамж гэх нийгмийн аюулгүйн сүлжээ болон асрамжийн газар болон ядуусыг хооллох төвөөр дамжуулан хоол хүнсээр хангах зэрэг шууд үзүүлэх тусламж үйлчилгээг хариуцна. Мөн тус яам нь цалингийн хамгийн доод хэмжээг тогтоох бөгөөд үүний хэрэгжилтийг ч мөн хариуцан ажиллана. Хуулийн дагуу цалингийн доод хэмжээ нь сарын 30 ам.доллар (30,000 төгрөг) байгаад Тусгай илтгэгч санаа зовниж байгаа бөгөөд энэ нь амьдралаа хэвийн авч явахад хүрэлцээгүй гэж Хүний эрхийн Үндэсний Комисс үзсэн байна.

35. Ядуурлыг бууруулахад Засгийн газраас баримтлах ерөнхий стратеги нь Эдийн засгийн өсөлтийг дэмжих, Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичигт туссан байна. Энэ стратегийн баримт бичиг нь хоол тэжээлийн дутагдлын асуудлыг цухас хөндөж, 1990–2002 оны хооронд нэг хүнд ногдох калорийн үндэсний дундаж хэмжээ нь үндэсний зохистой түвшнээс буурсан болохыг тэмдэглэсэн байна.<sup>34</sup> Энд олон тооны айл өрх хүнсний хомсдолд нэрвэгдсэн болохыг мөн ядуусын олонх нь хүнснийхээ хэрэгцээг нөхөж чадахгүй байгааг хүлээн зөвшөөрсөн байна. Гэвч стратегийн баримт бичигт баталгаагүй хүнсний шалтгаан нөхцлийг задлан шинжлээгүй, мөн хөдөө орон нутгийн болон ядуу хүмүүсийн дундах нөхцөл байдлыг эс тооцвол ижил түвшний орлоготой бусад орнуудтай харьцуулахад хоол тэжээлийн дутагдал нь Монгол Улсын хувьд ноцтой асуудал биш гэж үзсэн байгаа нь Тусгай илтгэгчийн санааг зовоосон болно.<sup>35</sup> Тусгай илтгэгчийн санааг зовоосон өөр нэг асуудал бол баталгаагүй хүнсний асуудал болон хоол тэжээлийн дутагдлыг бууруулах цөөн тооны бодит үйл ажиллагааг санал болгосон явдал байлаа. Уг стратеги нь эдийн засгийн шинэтгэл хийж, нийгэм хамгааллын бүтцийг боловсронгуй болгосноор эдийн засгийн өсөлт аяндаа бий болж, улмаар ядуурал аяндаа буурна гэсэн үзэл дээр тулгуурласан байна.<sup>36</sup> Гэтэл өмч хувьчлал, худалдааг либералчлах зэрэг эдийн засгийн шинэчлэлийн ихэнх нь өсөлтийг хүлээсэн хэмжээнд бий болгож чадаагүйгээс гадна эдийн засгийн өсөлтийн үр шим ядууст хүрэхгүй, тэгш бус байдал улам бүр өсч байгаа нөхцөлд ядуурал буурахгүй юм. Мөн үүний адилаар нийгэм хамгааллын бүтцийг оновчтой болгосон төдийд эдийн засгийн өсөлт аяндаа бий болох төлөвгүй байсан бөгөөд харин ч маш олон хүн тэтгэвэр тэтгэмжээс хамааралтай болсноор ядуурлыг улам ихээр бий болгож магадгүй юм. Эдгээрийг яамны ахлах албан

---

<sup>34</sup> Монгол Улсын Засгийн газрын Эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах стратеги (3 дугаар зүүлтийг үзнэ үү) 10 дахь тал

<sup>35</sup> Мөн тэнд, 135 дахь тал.

<sup>36</sup> Мөн тэнд, i тал.

тушаалтнуудаас хүлээн зөвшөөрч Монгол айл өрхийг ядуурлаас сэргийлэх, ядуурлын хэмжээг бууруулахад “амьжиргааг дэмжих” арга хэмжээ авч байгаа тухай Тусгай илтгэгчид мэдээлсэнд Тусгай илтгэгч сайшаасан болно.

36. Монгол Улсад шинээр байгуулагдсан Гамшигтай тэмцэх газар нь ган, зуд зэрэг байгалийн гамшигийн эсрэг урьдчилан сэргийлэх, онцгой байдлын үед хариу арга хэмжээ шуурхай авах тогтолцоог ханган ажиллах үүрэгтэй юм. Мөн энэ байгууллага нь шаардлагатай үед малын тэжээлийн хөтөлбөр, хүнсний тусламжийн хөтөлбөрүүдийг шуурхай зохион байгуулж ажилладаг. Гэхдээ Монгол Улсад хүнсний тусламжийн хөтөлбөрийг зохицуулах нэгдсэн зохицуулалт, хуваарилалт байхгүй байгаад Тусгай илтгэгч сэтгэл дундуур байлаа. Монгол Улс өнөө үед жилд харьцангуй их хэмжээний хүнсний тусламжийг Америкийн Нэгдсэн Улс, Франц зэрэг орнуудаас хүлээн авдаг. Эдгээр тусламжийн ихэнхийг нь онцгой байдлын хүнсний тусламж байдлаар тараахын оронд орон нутгийн хэмжээнд арилжиж, харин арилжааны орлогоос төслийн төсвийг санхүүжүүлдэг байна. Хүнсний тусламж Монгол Улсын эдийн засагт үзүүлэх нөлөөнд мониторинг хийх, мөн мөнгөн хэлбэрт оруулсан санхүүжилтийн тайлан тооцоог хөтлөх зэрэгт үүрэг хариуцлага огт орхигдсон байгаад Тусгай илтгэгч сэтгэл дундуур байв. Тиймээс хүнсний тусламжийн зарцуулалтыг тодорхой нэг байгууллагад хариуцуулах нь зөв бололтой.

37. Усны бодлогын зохицуулалтын хувьд Монгол Улсад усны асуудлыг бүхэлд нь хариуцсан яам байдаггүй ажээ. Усны үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх мөн яамдын өөр хоорондын үүрэг хариуцлагыг зохицуулах чиг үүрэг бүхий Усны үндэсний хороог байгуулсан бөгөөд жишээ нь Хүнс, хөдөө аж ахуйн яам нь хөдөөгийн усны хангамжийг хариуцдаг бол Байгаль орчны яам нь усны хадгалалт, нөөцийн асуудлыг хариуцдаг байна. Усны менежментийн бодлого хийгээд хариуцсан байгууллагуудын бүтэц сул байгаа нь уул уурхай болон бусад үйл ажиллагааны улмаас учрах усны бохирдлоос урьдчилан сэргийлэх зохицуулалтын чадавхид сөргөөр нөлөөлөхөөр байгаад сэтгэл зовниж байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас Засгийн газартай хамтран хот суурин газрын хүн амын ихэнх хувь хамаардаг хот суурин газар дахь байгалийн гүний худгуудын хамгаалалтыг сайжруулахаар ажиллаж байгаад Тусгай илтгэгч сэтгэл хангалуун байв. Гэхдээ хүн амын хамгийн ядуу хэсэгт усыг зохистой хэмжээнд хүртээмжтэй хангах асуудлыг нэгтгэн хариуцах зохицуулалт байхгүй байгаад сэтгэл дундуур хэвээр үлдсэн юм.

### **В. Олон улсын байгууллагууд болон хандивлагчид**

38. Монгол Улсад олон талт хөгжлийн банкууд (Дэлхийн Банкнаас илүү Азийн хөгжлийн банкны оролцоотой) зэрэг олон тооны олон улсын байгууллага, Нэгдсэн Үндэстний Байгууллагын харьяа байгууллагууд, Бээжин дэх салбар болон Монгол Улс дахь төлөөлөгчөөрөө дамжуулан харилцаатай байдаг НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага зэрэг төрөлжсөн байгууллагууд үйл ажиллагаагаа явуулдаг юм байна. Монгол Улс дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын харьяа байгууллагууд голчлон хөгжилд хандсан хүний эрхийг голчилдог хэдий ч хоол хүнсээр хангагдах эрхэд анхаарлаа төдийлөн хандуулж байгаагүй байна.



39. Монгол Улс нэг хүнд оногдох олон улсын тусламжийн хэмжээгээр дэлхийд дээгүүрт ордог. Үндэсний нийт бүтээгдэхүүнийх нь 20 хувь нь гадны тусламж эзэлснээр тусламжаас хамааралтай дэлхийн тав дахь улс болж байна.<sup>37</sup> 1991 оноос 2002 он хүртэлх хугацаанд Монгол Улс хоёр талт болон Олон талт албан ёсны хөгжлийн тусламжийн хүрээнд 2,4 тэрбум ам доллар авсны тал орчим хувь нь буцалтгүй тусламж хэлбэрээр, тал орчим хувь нь эргэн төлөгдөх хөнгөлөлттэй зээл хэлбэрээр авсан байна.<sup>38</sup> Монгол Улс бараг Зөвлөлт Холбоот Улсаас авч байсан татаастай тэнцэх хэмжээний тусламжийг авсан боловч ядуурлыг бууруулахад мэдэгдэхүйц нөлөө үзүүлсэнгүй. Тусламжийн ихэнхийг тухайлан ядуурлыг бууруулахад зарцуулж байгаагүй байна. 1990–ээд оны үед зээл, тусламжийн ихэнх хувь нь дэд бүтэц (37%), эдийн засгийн менежментэд (24%) хуваарилагдсан бол нийт зээл тусламжийн дөнгөж 1,2%–ыг Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрт, хэдийгээр хөдөө аж ахуйн салбарт ажил эрхлэлт өссөөр байхад зөвхөн 5%–ыг л газар тариаланг хөгжүүлэхэд зарцуулсан байна.<sup>39</sup> Эндээс харахад ядуурлыг бууруулах, хүнсний аюулгүй байдлыг хангах нь олон улсын голлох хандивлагчдын, тэр дундаа Азийн хөгжлийн банк болон Дэлхийн банкны тэргүүлэх чиглэлд ордоггүй байсаар иржээ. Гэвч олон талт хөгжлийн банкууд эдийн засгийн өсөлтөөс гарах ашиг ядууст хүрнэ гэж найдахаас илүүтэй ядууралд анхаарал хандуулах шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрч эхэлснээр энэ байдал одоо өөрчлөгдөж байгаа бололтой. НҮБ–ын Хөгжлийн хөтөлбөр, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага зэрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын харьяа олон байгууллага хэдийгээр хүнсний аюулгүй байдал, тэжээлийн байнгын дутагдлын асуудалд анхаарахгүй байгаа ч ядуурлыг бууруулахад чиглэсэн тусламжийн зарцуулалтын зориулалтыг дахин тогтоохоор чармайж байна.

### **С. Төрийн бус байгууллагууд**

40. Шилжилтийн үеэс хойш Монгол Улсад иргэний нийгмийн байгууллагуудын хөгжилд чухал ахиц дэвшил гарсаар байна. Гэхдээ эдгээр байгууллагын олонх нь хөгжил муутай, нөлөөллийн чадавх, ялангуяа ядуучуудын төлөө явуулах нөлөөллийн чадавх сул хэвээр байна. Мөн Монгол Улсад маш олон тооны олон улсын төрийн бус байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагийн олонх нь үйл ажиллагаандаа хүний эрхэд суурилсан хандлагыг хэрэгжүүлж байгаа боловч цөөхөн тооных нь л хоол хүнсээр хангагдах эрхэд анхаардаг байна. Тусгай илтгэгч Хүний эрх, хөгжил төв, Монголын хүнс үйлдвэрлэгчдийн холбоо зэрэг дотоодын байгууллага, мөн Action Contre la Faim, Дэлхийн зөн зэрэг олон улсын төрийн бус байгууллагуудын төлөөлөлтэй уулзалт хийсэн юм. Эдгээр байгууллага бүгдээрээ Монгол Улсад тэжээлийн дутагдал асуудал болоод байгааг хүлээн зөвшөөрч, хөгжлийн голлох хандивлагчдын анхааралд орохгүй байгаад санаа зовниж буйгаа илэрхийлсэн. Дэлхийн зөнгийн төлөөлөгчийн хэлснээр тухайлбал өвлийн хүйтнийг үл

---

<sup>37</sup> Мак Кинли, “Үндэсний хөгжлийн стратеги болон зээл тусламжийн зохицуулалт,” Грифиний эмхэтгэл (6 дугаар зүүлтийг үзнэ үү) 136 дахь тал.

<sup>38</sup> “Монгол Улс дахь Эдийн засгийн эмзэг байдал ба хүний аюулгүй байдал” (2 дугаар зүүлтийг үзнэ үү) 33 дахь тал.

<sup>39</sup> Мак Кинли, (37 дугаар зүүлтийг үзнэ үү) 138 дахь тал

харгалзан өдөрт ганц удаа идэх хоолны төлөө Улаанбаатарт байдаг Дэлхийн зөнгийн хоолны хоёр газарт олон хүн цаг шахам алхаж ирдэг байна.

#### IV. ГОЛ БАРИМТУУД БОЛОН АНХААРАХ ЗҮЙЛС

##### **А. Хоол хүнсээр хангагдах эрхийн хэрэгжилтийн дэвшил**

41. Хоол хүнсээр хангагдах эрхийг хэрэгжүүлэх үүргийнхээ дагуу хоол хүнсээр хангагдах эрхийг Монгол Улсын Засгийн газар боломжтой бүх нөөц боломжоо дайчлан шат дараатайгаар хэрэгжүүлэх шаардлагатай. Энэ нь хоол хүнсний олдоц, хүртээмж, зохистой байдлыг сайжруулах, мөн нэн эмзэг бүлэгт анхаарал хандуулж хүнсний баталгаагүй байдал, хүнсний гачигдал, ядуурлын түвшинг бууруулахад тогтвортой ахиц гаргах ёстой гэсэн үг.

42. Тэжээлийн архаг дутагдал 1990–2000 оны хооронд 34%–аас 38% болж өнгөрөгч арван жилд буурсан гэхээсээ илүү өссөнөөр хоол хүнсээр хангагдах эрхийн хэрэгжилтэд ухралт болсонд тусгай илтгэгч санаа зовниж байна. 1990 оноос өмнө тэжээлийн дутагдал ховор тохиолддог байсан бол НҮБХХ–ийн мэдээллээр ядуурал, ажилгүйдлийн тохиолдол огт тэмдэглэгдээгүй байгаад Тусгай илтгэгч санаа ихээхэн зовниж байна.<sup>40</sup> Өнөөдөр эдийн засгийн шилжилт эхлээд 14 жил болоход монголчуудын 35%–аас илүү хувь нь амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур түвшинд байгаа нь хоол хүнсний хомсдолд аж төрж байна гэсэн үг. Хэдийгээр амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур түвшинд амьдарч байгаа хүмүүсийн тоо хэмжээ тогтворжсон мэт байгаа ч тэгш бус байдал, ядуурал улам гүнзгийрч байгаа талаар мэдээлэх болсон байна. Үүнээс харахад ядуучууд нь улам ядуурч, ирээдүйд хоол хүнснийхээ зардлыг гүйцэхгүй болох төлөв харагдаж байна. Засгийн газар хоол хүнсний нөөц боломж, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах шаардлагатай алхмуудыг авч байгаа ч Хүнсний аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр тэжээлийн дутагдал буюу хүнсний хүртээмжийн асуудалд анхаарахгүй байгаад Тусгай илтгэгч сэтгэл зовниж байна.

43. Монгол Улсын тэжээлийн байнгын дутагдалтай байдалд анхаарал хандуулж, нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглахгүй байгаад тусгай илтгэгч санаа зовниж байна. Монгол Улс нэг хүнд оногдох гадаадын зээл тусламжийн байдлаар дэлхийд хамгийн дээгүүрт ордог атал эдгээр санхүүжилтийн ихэнхийг хүнсний аюулгүй байдлыг сайжруулах, ядуурлыг бууруулахад ашиглахгүй байна. Нэн ядуу бүлэгт очих хоол хүнсний хүртээмжийн асуудал дээр тоотой хэдхэн арга хэмжээ авч, цөөхөн байгууллага анхаарч байна. Энэ нь нэг талдаа хандивлагчид, ялангуяа олон улсын хөгжлийн банкууд хүнсний аюулгүй байдалд анхаарал бага хандуулж байгаатай холбоотой байж магадгүй. Нөгөө талаас энэ нь том бизнесийг дэмжсэн эдийн засгийн бодлогод найдлага тавьсанаас шалтгаалж байгаа ч Монголын ядуу, хүнсний гачаалтай хэсэгт хангалттай хүрч чадахгүй байна. Тусгай илтгэгч мөн баян хоосны хооронд, бүс нутгуудын хооронд, эрэгтэй эмэгтэйчүүдийн хооронд тэнцвэргүй байдал ихэсч байгаад сэтгэл зовниж байна.

---

<sup>40</sup> Монгол Улсын Хүний хөгжлийн илтгэл, 2003 он (14 дүгээр зүүлтийг үзнэ үү) 36 дахь тал.

44. Хоол хүнсээр хангагдах эрхийн эрх зүйн зохицуулалтын тухайд тусгай илтгэгч хоол хүнсээр хангагдах эрхийг оруулаад бүхий л хүний эрхийг хариуцсан чиг үүрэг бүхий Хүний эрхийн Үндэсний Комиссыг байгуулсан хийгээд тус Комиссын ядуурлын асуудлаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааг сайшаасан болно. Ядуурлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хүрээнд хоол хүнсээр хангагдах эрхийн тал дээр Комиссын хийх ажлыг Тусгай илтгэгч дэмжих бөгөөд энэ нь Монгол Улс дахь хоол хүнсээр хангагдах эрхийн хэрэгжилтэд тавих дотоодын хяналтыг сайжруулах, мөн хоол хүнсний талаарх эрхийн хэрэгжилтийн нөхцлийг сайжруулах, үүнтэй холбоотой хариуцлагыг нэмэгдүүлэх нэгэн чухал арга зам байх болно хэмээн үзэж байна.

#### **В.Хоол хүнсээр хангагдах эрхийн зөрчил**

45. Хоол хүнсээр хангагдах эрхийн талаар хүлээсэн үүргийнхээ дагуу Засгийн газар аливаа ялгаварлан гадуурхалтгүйгээр энэ эрхийг хүндэтгэн, сахин хамгаалж, хэрэгжүүлэх үүрэгтэй. Хоол хүнсээр хангагдах эрхийг зөрчсөн баримттай тохиолдол харьцангуй цөөн байсанд Тусгай илтгэгч талархалтай байсан бөгөөд хоол хүнсээр хангагдах эрхийг нь зөрчих хүртэл даамжирсан аливаа үндэсний болон бусад цөөнхийн эсрэг өргөн хүрээтэй ялгаварлан гадуурхалт гарсан байж болох цөөн тооны баримт олсон болно. Тусгай илтгэгч нэгэн хорих ангид очиж хүмүүжигчдийн хоол хүнсний нөхцлийг шалгахад гал тогооны нөхцөл сайн, хорих анги хүмүүжигчдэд өгдөг хоолны чанар, хэмжээ зохих түвшинд байна гэж дүгнэв.

46. Гэхдээ зарим хүн өлсөж үхсэн, байнгын тэжээлийн дутагдалд орсон, нийгмийн халамжийн гадна үлдсэн зэрэг бодитой баримт бүхий зөрчлийн талаар мэдээлэл авсан юм. Монгол Улс дахь хүний эрхийн нөхцөл байдлын талаарх сүүлчийн илтгэлдээ Хүний эрхийн Үндэсний Комисс мэдээлсэнээр:

“Улаанбаатар хотод явуулсан судалгааны үеэр олон хоногийн турш хоолгүй байж, тэжээлийн дутагдалд орсноос дэмийрч солирсон хүмүүсийн тухай мэдээлэл тэмдэглэгдсэн. Сонгинохайрхан дүүргийн Халамжийн төвд 56 настай иргэн Г хүнсний гачигдалд нэрвэгдсэний улмаас ухаан самуурч өвдсөн ажээ” гэсэн байна.<sup>41</sup>

47. Албан ёсоор бүртгүүлээгүй шилжин суурьшигчид, ганц бие эхчүүд, өрх толгойлсон эмэгтэйчүүд, гудамжны хүүхдүүд, цаатангууд, бичиг баримтгүй хүмүүс зэрэг нийгмийн тодорхой бүлгүүд заримдаа нийгмийн халамж, үйлчилгээний гадуур үлддэг явдал байна. Хүний эрхийн Үндэсний Комиссын мэдээлсэнээр ядуу иргэдийн 41% нь бичиг баримтгүй, 42 буюу талаас илүү хувь нь хуулиар эдлэх ёстой эрхийнхээ талаар ойлголтгүй байдаг ажээ. Мөн санаа зовоосон өөр нэг асуудал бол зарим бүлэг, ялангуяа эмэгтэйчүүд, шилжин суурьшигчид, хөдөөгийн болон гэр хорооллын хүн ам, байр түрээслэгчид хувьчлалын үйл явцад ялгаварлагдан үлдсэн байна. Улаанбаатар хотод жишээ нь байранд оршин суугчид орон сууцаа үнэ төлбөргүй хувьчлан авсан байхад ойролцоох гэр хорооллын оршин суугчид үүнтэй адил ашиг буюу газраа өмчилж аваагүй байна.

48. Газар хувьчлалын хуулийг эсэргүүцсэнтэй холбоотой зөрчил гарсан баримтууд ч бас байна. 2003 оны 4 дүгээр сард Улаанбаатар хотод газар тариаланчдын эсэргүүцлийн

---

<sup>41</sup> Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл (30 дугаар зүүлтийг үзнэ үү) 33 дахь тал

суултад оролцсон дөрвөн хүнийг цагдаа нар зодсон боловч Засгийн газрын зүгээс энэ асуудлыг шалгасан эсэх талаар ямар ч мэдээлэл байхгүй байгаа нь иймэрхүү зөрчлийн үед ял завшдаг, хариуцлага тооцохгүй орхидог явдлыг өөгшүүлж байгаа хэрэг хэмээн Эмнести Интернешнл мэдээлсэн юм.<sup>42</sup> Мөн 2002 оны 11 дүгээр сард газар хувьчлалын хуулийг эсэргүүцсэн жагсагчидтай зүй бус харьцсан асуудлыг хангалттай мөрдөн шалгахгүй байгаатай холбоотой асуудал ч байсаар байна.

### **В. Хоол хүнсээр хангагдах эрхийн хэрэгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээлүүд**

49. Хоол хүнсээр хангагдах эрхийг шат дараатай хэрэгжүүлэх Засгийн газрын чадавхид нөлөөлж байгаа олон тооны саад бэрхшээл байна хэмээн Тусгай илтгэгч үзэж байна.

50. Монгол Улсад хоол хүнсээр хангагдах эрхийг бүрэн хэрэгжүүлэхэд тулгарч байгаа эхний саад бол баталгаагүй хүнс болон байнгын тэжээлийн дутагдлын асуудалд хангалттай анхаарал тавихгүй байгаа явдал мөн. Засгийн газар ОУВС-ийн болон Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк зэрэг олон улсын хөгжлийн банкны зөвлөгөөгөөр “шок эмчилгээ,” эрчимтэй өмч хувьчлал, худалдааг либералчлах зэрэг арга замаар ард түмний өөрсдөө амь зуух чадавхид хэрхэн нөлөөлж байгаад хяналт тавилгүйгээр эдийн засгийн чиг баримжаагаа өөрчлөхөд голлон анхаарах хандлагатай явж ирсэн байна. Нийгмийн тэгш байдал буюу хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах тал дээр гарах хохирлыг харгалзахгүйгээр хөгжилд чиглэсэн бүх хүч чармайлтаа өмч хувьчлал болон эдийн засгийн өсөлт дээр төвлөрүүлж иржээ. Аж үйлдвэрлэлийн салбар огцом унаснаар Монгол Улс түүхий эдийн бүтээгдэхүүний экспортоос хараат болж, дагнан хүнс экспортлогч байснаа удалгүй хүнсний хэрэглээнийхээ 70% гаруйг импортолдог орон болж хувирсан байна. Өмч хувьчлал, худалдааг либералчлах зэрэг алхам нь ил тод, ядуусыг дэмжсэн эдийн засгийг үүсгээгүй бөгөөд эдийн засагт шинээр гарсан урсгалын ихэнх хэсэг нь алтны уурхайгаас гарах ашгаас ирэх болж, харин үр шим нь тэнцвэргүй хуваарилагдаж, тогтвортой бус байна.

51. Үйлдвэрлэл улам бүр уналтад орсон нь ашиг орлого, цалин хөлс буурах, ажилгүйдэл газар авах зэрэгт нэрмээс болж, хоол хүнсээр хангагдах эрхийн хэрэгжилтэд голлох саад тотгор болсоор байна. Ядуурал, хүнсний гачигдалтай тэмцэхэд том бизнесийг дэмжих эдийн засгийн загвар дээр тулгуурласан бодлого нь амжилт авчраагүй л байна. Гриффиний тэмдэглэснээр “Төр, хөндлөнгөөс үл оролцох бодлого, ядуурлыг бууруулахад минималист зах зээлийн механизм дээр дан ганц тулгуурлахыг зөвтгөгчид тус улсыг сүйрлийн ирмэг дээр аваачжээ.”<sup>43</sup> Шилжилтийн эхний жилүүдэд “зах зээлийн эдийн засагт төрийн оролцоо, зохицуулалтыг үгүйсгэж, шилжилтийн үеийн “шок эмчилгээ”-ний арга хэрэглэсэн зэрэг нь эдийн засгийн бүхий л салбарт уналт, эмх замбараагүйтэл үүсгэснийг сүүлийн үеийн Засгийн газрын баримт бичгүүдэд тэмдэглэх болсон байна.”<sup>44</sup> Либералчлалын хурд нь Монгол Улсын аж үйлдвэрийн системийг үр ашигтайгаар өөрчилж, дэлхийн нээлттэй зах зээлд тэсч үлдэх боломжийг олгосонгүй. Өмч хувьчлал

<sup>42</sup> <http://web.amnesty.org/report2004/mng-summary-eng>.

<sup>43</sup> Гриффиний эмхэтгэл (6 дугаар зүүлтийг үзнэ үү), xvii тал.

<sup>44</sup> Санхүү, эдийн засгийн яамны Монголын зөвлөлдөх бүлгийн “Монгол Улс дахь Эдийн засгийн эмзэг байдал

ч өсөлтийг аяндаа дагуулсангүй, хувьчлагдсан олон өмч хөрөнгө өмнө нь хариуцаж байсан хүмүүстэй буюу өмнөх менежерүүд, Засгийн газрын хуучин албан хаагчдын гар дээр очсон боловч хувийн бизнес эрхлэх чадвар, чадавхыг бий болгох буюу хөгжлийг дэмжихэд зохистой санхүүжилтийг хангах оролдлого тун цөөхөн гарчээ. Эдийн засаг хүн амын гуравны хоёрыг баталгаагүй хүнсний асуудал болон ядуурлаас гаргахад шаардлагатай ажлын байраар хангах чадваргүй хэвээр үлджээ.

52. Төрөөс малчдын амьжиргааг дэмжсэн хөрөнгө оруулалт дутмаг байгаа нь хоол хүнсээр хангагдах эрхийг хэрэгжүүлэх, ялангуяа шаардлагатай ажлын байрыг бий болгоход чиглэсэн “бэлчээр хамгааллын сүлжээ”-г байгуулахад тулгарч буй гол саад бэрхшээл болж байна. Нэгдлүүд тарснаар малчид аж төрөхөд шаардлагатай нийгмийн шинжтэй үйлчилгээ, ялангуяа хахир хатуу өвөл, ус, өвөлжөө, онцгой тохиолдолд хэрэглэх тэжээлийн хангалт зэрэг үйлчилгээгүй хоцорчээ. Эдгээр үйлчилгээг үзүүлэх хамтын ямар нэг байгууллага байхгүйгээр мал аж ахуй эрхлэх нь цөөн тооны малтай иргэдэд бэрх асуудал болсон байна. Гэвч бэлчээрийн мал аж ахуй нь ядуу зүдүү монголчуудын хувьд нийгэм хамгааллын салшгүй нэг хэсэг болж хүн амын 45%-ийг ажлын байраар хангаж, голлох баялгийн эх үүсвэр болох газрын хамгийн өгөөжтэй ашиглалтыг хангаж байгаа юм. Өнөр гэр бүлийн доторх эв нэгдэл, хөдөө хотыг холбосон холбоо нь хотын айлуудын наад захын мах, сүүний хэрэгцээг хангасаар байна. Хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөний урсгалыг зогсоохын тулд ялангуяа хотын ажилгүйдэл өндөр түвшинд байсаар, хот доторх ядуурал хөдөө дэх ядуурлаас их байгаа нөхцөлд бэлчээрийн малчдын амьжиргааг дэмжих нь зайлшгүй авах шаардлагатай арга хэмжээ мөн. Ядаж л хот сууринд хангалттай ажлын байр бий болтол бэлчээрийн мал аж ахуйд хөрөнгө оруулж, тэтгэх нь зүйтэй. Амин зуулга хангах төдий түвшин ч гэсэн огт амин зуулгагүй байснаас дээр юм.

53. Монголын хээрийн экосистем нь бэлчээрийн даац хэтрэх, бэлчээр доройтох, ой мод огтлох зэрэгт эмзэг хэврэг атал өнөөгийн газрын тухай хууль бэлчээрийн даац хэтрэхэд нэрмээс болж байгалийн гамшигт эмзэг өртөмтгий байдлыг нь улам бүр нэмэгдүүлсээр байна. Газрын тухай 1994 оны хууль нь бэлчээрийн ашиглалтыг “эзэнгүй” болгож үүний үр дүнд газар ашиглалтад тавьсан ямар нэг хязгаарлалт байхгүй тул хамгийн эрэлттэй газруудад бэлчээрийн даац хэтрэхэд хүргэсэн байна. Одоо зарим хүн бэлчээрийн даац хэтэрсэн асуудлыг шийдвэрлэхийн тулд газрыг хувьчлах санал дэвшүүлж байна. Гэхдээ газар хувьчлах нь уур амьсгалын шинжтэй эрсдлийг даван туулахад хол зайд отор хийх шаардлагатай болдог мал аж ахуйн хувьд тохирох шийдэл биш юм. Зөв хувилбар нь “эзэнгүй ашиглах” болон хувь хүний өмчлөлд оруулах хоёрын аль нь ч байж болохгүй бөгөөд гуравдагч хувилбар бол тодорхой нэг бүлэгт газрын эрхийг өгч, бүлэг нь гишүүдийнхээ үйл ажиллагааг зохицуулж, тухайн бүлэгт хамааралгүй хүн тэр газрын ашиглалтаас гадуур байх дундын өмчлөлийн хэлбэр.<sup>45</sup> Нийт дундын өмчлөлийн хэлбэр нь дөрвөн улирлын улирал тус бүрд шаардлагатай өөр өөр хэв шинж бүхий бэлчээр, усны эх үүсвэр ашиглах эрх, мөн бүлгийн газар эзэмших

---

ба хүний аюулгүй байдал” (2 дугаар зүүлтийг үзнэ үү!) 36 дахь тал,

<sup>45</sup> А.Иковиц, “Ядуурал ба хүрээлэн буй орчин” Гриффиний эмхэтгэлд (6 дугаар зүүлтийг үзнэ үү) 97–99 дэх тал

эрхийг нь баталгаажуулах, бэлчээр талхлагдахаас сэргийлэх бөгөөд зах зээлээс хол, дэд бүтэц тааруу, тохиромж муутай хэсэгт хураамж бага, гарц сайтай, зах зээлд ойр, дэд бүтэц сайтай хэсэгт хураамж өндөр байх түрээсийн тогтолцоон дээр үндэслэсэн улирлын шинжтэй бэлчээр ашиглах эрх байж болох юм.<sup>46</sup> Бэлчээрийн нүүдлийн аж ахуй нь задгай хээр талд тохирч, Монголын уудам газар нутгийг ашиглах хамгийн зохистой арга хэлбэр байж магадгүй ч энэ нь бэлчээрийн элэгдлээс зайлсхийхийн тулд зохистой хэмжээнд нүүдэллэж, дан ганц эдийн засгийн өсөлт гэхээсээ илүү тогтвортой байдал, бүх нийтийн хүнсээр хангагдах эрхэд л анхаарал хандуулсан нөхцөлд л бат тогтвортой байж болох юм.

54. Монгол Улсын хувьд худалдааг бүрэн либералчилснаар эдийн засгийн өсөлт бий болгоход хүндрэл учруулсан, дэлхийн худалдаанд оролцоход ихээхэн сул тал болохуйц олон тооны саад тотгор бий. Монгол бол тун цөөхөн авто зам, төмөр замын сүлжээ бүхий үндэсний болон олон улсын зах зээлд нэвтрэх тун тааруухан дэд бүтэц бүхий газар зүйн хувь алслагдан тусгаарлагдсан маш том нутагтай, далайд гарцгүй орон юм. Энэхүү алслагдмал авто замын сүлжээний хангалтгүй байдал зэргээс үүдсэн тээврийн зардлаас болоод аль ч бараа бүтээгдэхүүний өрсөлдөөнд сөргөөр нөлөөлдөг. Эдгээр саад бэрхшээлээс шалтгаалж Монгол Улсын хувьд дэлхийн худалдааны системд нэг ижил боломжтойгоор нэвтрэх нь түвэгтэй болдог бөгөөд үүнийг хүлээн зөвшөөрч, чөлөөт худалдаанд хохирлыг нь тэнцэтгэх зүйтэй юм. Гэвч Монгол Улсыг эдийн засагтаа тавьсан хамгаалалтаа багасгахыг ятгаж, хэт хурдацтайгаар либералчлахад хүргэсэн бөгөөд үйлдвэрүүдийнх нь ихэнх нь үр ашигтай ажиллаж чадалгүйгээр хаалгаа барьж Монгол Улсын хувьд дэлхийн зах зээл дээр өрсөлдөх зүйл үлдээгүй ажээ. Либералчлал нь өсөлтийг аяндаа бий болгоно гэж таамаглаж байсан ч Хятад, Орос гэсэн аварга хөршүүдийнх нь, ялангуяа хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүний ширүүн өрсөлдөөний түрэлтэд тэсэх боломж тун бага байлаа. Одоо Дэлхийн худалдааны байгууллагын шаардсанаас ч илүүгээр либералчлагдсан Монгол Улсад шинэ үйлдвэр барьж байгуулахад амаргүй байх болно. Ноолуур, зэс, алтнаас голлон хамааралтай болсон Монгол Улс дэлхийн бараа бүтээгдэхүүний үнэ хэлбэлзэхэд тун эмзэг болсон атал хүнсний зүйлийг гадаадаас авахад гадаад валютын нөөц хэрэгтэй байх болжээ.

55. Арав гаруй жилийн эдийн засгийн уналтын дараа дэлхий дээр зээл тусламжийг хамгийн өндөр түвшинд авдаг орнуудын нэг болсон боловч Монгол Улсын эдийн засагт сэргэлт дөнгөж л гарч эхэлж байна. Монгол Улсад олон улсын зээл тусламж хэрэгтэй байхын хажуугаар зээл тусламжаас хэт хамааралтай болж, тэрхүү тусламж нь ядууст хүрдэггүй болох аюул байсаар байна. Монгол Улсын гадаад өр 1.3 тэрбум ам доллар байгаа нь үндэсний нийт бүтээгдэхүүнийх нь 90% болж байна.<sup>47</sup> Өрийн дарамт хоол хүнсний хангамжийн эрхийг хэрэгжүүлэхэд ирээдүйд саад болж, цаашилбал ядууралтай тэмцэх, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах нөөц боломжид тушаа болох болно.

<sup>46</sup> Грифин, "Хотоос хөдөө рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөн", (6 дугаар зүүлт), 69 дэх тал

<sup>47</sup> "Монгол Улс дахь Эдийн засгийн эмзэг байдал ба Хүнсний аюулгүй байдал" (2 дугаар зүүлтийг үзнэ үү), 30, 33 дахь тал.

## V. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖҮҮД

56. Засгийн газраас хоол хүнсээр хангагдах эрхийн тухай илүү тодорхой ойлголттой болох сонирхлыг тусгай илтгэгч сайшааж байна. Тусгай илтгэгч хүнсний (хангамж, чанар) хүртээмж, нийлүүлэлтийг сайжруулахаар Засгийн газраас чармайж байгаад сэтгэл хангалуун байна. Гэвч хүнсний хүртээмж тааруу байгаа асуудал, мөн түүнээс үүдсэн тэжээлийн архаг дутагдалд нэн даруй анхаарал тавих шаардлагатай бөгөөд зуд зэрэг байгалийн гамшигийг эрт үед анхааруулах механизм, урьдчилан сэргийлэх арга хэмжээ зэрэгт ч анхаарах хэрэгтэй гэж үзэж байна.

57. Тусгай илтгэгч дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

(i) Одоогийн статистик тоо баримт цаг үедээ нийцэж байгаа эсэх, асуудлын тулгамдсан байдлыг тодорхойлохын тулд баталгаагүй хүнс, тэжээлийн байнгын дутагдал зэрэгт дэлгэрэнгүй судалгаа хийх хэрэгтэй. Ядуурал болон хоол хүнсний хүртээмж муу байгаагийн хоорондох холбоог судалбал зохино. Байнга өлөн зэлмүүн явах нь тэжээлийн дутагдалд ороход хэрхэн нөлөөлж байгааг Тэжээлийн дутагдлын талаарх ирээдүйд хийх судалгаа нь хамарч судлах ёстой.

(ii) Дотоодын хууль тогтоомжийн дагуу хоол хүнсээр хангагдах эрхийн эрх зүйн зохицуулалтыг бэхжүүлэх хэрэгтэй. Олон улсын болон дотоодын хууль тогтоомжийн хоорондын уялдаа холбоог тодорхой болгож, Хүнсний тухай 1995 оны хуульд бүх монголчуудад хүрэлцээтэй хэмжээний хүнсээр хангагдах эрхтэй болохыг хүлээн зөвшөөрсөн нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг алхмыг хийх хэрэгтэй. Хэрэв хоол хүнсээр хангагдах эрхийг нь хэрэгжүүлэхгүй тохиолдолд эрхээ сэргээлгэх боломжийг нь хангахын тулд хариуцлага тооцох механизмыг бий болговол зохино. Засгийн газар нэгдэн орсон олон улсын хүний эрхийн гэрээнүүдэд заасан хүний эрхийн хэрэгжилтийн талаар хугацаа хожимдоод байгаа илтгэлүүдийг өргөн барих хэрэгтэй.

(iii) Хүний эрхийн Үндэсний Комиссын зөв зүйтэй үйл ажиллагааг дэмжиж, бэхжүүлэх хэрэгтэй. Комисс нь хоол хүнсээр хангагдах эрхийн хэрэгжилтэд амин чухал үүрэгтэй бөгөөд энэ асуудлаар судалгаа, мониторинг явуулах, гомдол хянан шийдвэрлэх байгууллагын чадавхи бэхжүүлэх шаардлагатай. Үүнд монгол ядуу иргэдийн хоол хүнс, усны хүртээмжийн байдал, ийнхүү хүртээмжтэй байлгах аас хүмүүс татгалзсан, турж үхсэн тохиодлуудад мониторинг хийх, мөн тэжээлийн байнгын дутагдалтай тэмцэх тэмцлийн хүрээнд хангалттай хоол хүнсээр хангагдах эрхийн шат дараатай хэрэгжилтэд мониторинг хийх зэрэг орно.

(iv) Засгийн газрын бодлого, хөтөлбөрүүдийг баталгаагүй хүнс болон Монгол Улсын хүн амын хоол хүнсний хүртээмжийн тааруу байдалд анхаарахаар боловсруулах шаардлагатай. Яамд хоорондын хүлээх хариуцлагыг бүрэн хэмжээнд тогтоовол зохино. Баталгаагүй хүнсний асуудлыг шийдвэрлэх ажлыг Ядуурлыг бууруулах үндэсний стратегитай бүрэн уялдуулах хэрэгтэй юм. Олон улсын хандивлигчидтай хамтран Засгийн газар хангалттай хэмжээний нөөцийг нэн эмзэг бүлгийнхэнд чиглүүлж, хүнс, усыг шударга хуваарилахыг гол зорилт болгон ялангуяа ядуурлыг бууруулж, хүнсний аюулгүй байдлыг сайжруулахад зарцуулж, олон улсын зээл тусламжийг шударгаар хуваарилахыг

эрхэмлэх хэрэгтэй.

(v) Хөдөөгийн амьжиргааг дэмжиж, худаг ашиглалт, онцгой байдалд хэрэглэх өвс тэжээлийн нөөц, өвөлжөө, мал эмнэлгийн үйлчилгээ зэрэг нийгмийн шинжтэй эд зүйлс, наад захын үйлчилгээний хүртээмжийг сайжруулахын тулд бэлчээр дагасан бүтцүүдийг байгуулахыг дэмжихэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг ихээр хийх хэрэгтэй.

(vi) Бэлчээрийг хувьчлах нь даац хэтрэх асуудлыг шийдвэрлэхээсээ илүү баталгаагүй хүнс болон ядуурлыг нэмэгдүүлэх учраас ирээдүйд бэлчээрийг хувьчлахгүй байх. Бэлчээрийн даац хэтрэлтийг шийдвэрлэх буюу тогтвортой байдлыг сайжруулахад дундын өмчлөл, нүүдлийн хэлбэрийн байгууллага, нэгжийг байгуулах асуудлыг авч үзэх хэрэгтэй юм.

(vii) Усны нөөцийн менежментийн бүтцийг бэхжүүлж, хөдөөгийн хүн ам болон малд зориулсан худаг, Улаанбаатарын гэр хороолол зэрэг хот суурин газар амьдарч байгаа хүмүүсийн усан хангамж зэрэг бүх нийтэд зориулж усаар баталгаатай хангах үүрэг хариуцлагыг хуваарилах. Мөн усны чанарыг сайжруулах шаардлагатай.

(viii) Хүнсний тусламжийн удирдлагыг хангахын тулд бүх нийтийг хамарсан хариуцлагыг тодорхойлох хэрэгтэй. Хүнсний тусламжийг нутгийн үйлдвэрлэлийг өсөн нэмэгдүүлэх хүч чармайлтад тээг болгохгүйн тулд хүнсний аюулгүй байдал болон эдийн засагт илүү нөлөөлөл үзүүлэх хүнсний тусламжийн үр нөлөөнд хяналт тавих механизмыг бий болгох нь зүйтэй. Хүнсний тусламжийг мөнгөн хэлбэрт шилжүүлэлтийг илүү ил тод болгох болон хариуцлагыг сайжруулахын тулд стандарт журмыг боловсруулан мөрдөх хэрэгтэй юм.

(ix) Албан ёсоор бүртгүүлээгүй шилжин суурьшигчид, баримт бичиггүй айл өрх зэрэг бүх л бүлэг нийгмийн хангалттай халамж үйлчилгээ авах баталгааг хангахын тулд арга хэмжээ авах хэрэгтэй. Одоогийн нийгэм хамгааллын тогтолцооны шинэчлэлд хүнсний аюулгүй байдалд үзүүлэх боломжит нөлөөг судлах судалгаа багтах шаардлагатай байна.

(x) Эдийн засгийн цаашдын шинэчлэл нь ялангуяа эмэгтэйчүүдийг нэрвэсэн худалдааны либералчлал, өмч хувьчлалын шинж болсон тэгш бус байдлаас хамгаалах, мөн шинэчлэлийн үр дүнд тэжээлийн дутагдлыг газар авахуулахгүйн тулд хяналт тавих хэрэгтэй юм. Авлига, тал харах магадлалыг арилгахын тулд хариуцлага, ил тод байдлыг сайжруулах шаардлагатай байна.

(xi) Эцэст нь эдийн засгийн хөгжлийн одоогийн загварыг ядуурал болон тэжээлийн дутагдлын асуудалд хандуулж өөрчлөх хэрэгтэй юм. Эс бөгөөс Монгол Улс дахь ядуу, хүнсний хомсдолтой хүмүүс анхаарлын гадна хаягдах шинжтэй байна.

Монгол Улсын заяагдмал шинжтэй саад бэрхшээл бол алслагдмал, далайд гарцгүй орон болохыг олон улсын түвшинд таниулж, чөлөөт худалдааны журам нь хөгжил болон хоол хүнсээр зохистой хангагдах эрхийг хэрэгжих боломж олгох шаардлагатай. Хоол хүнсээр хангагдах эрхийг хэрэгжүүлэхийн тулд эн тэргүүнд баталгаагүй хүнс болон ядууралд анхаарах хэрэгтэй байна.



## 10.2 НҮБ–ЫН ЭРҮҮ ШҮҮЛТИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН ТУСГАЙ ИЛТГЭГЧ МАНФРЕД НОВАКИЙН ТАЙЛАН

### Хураангуй

Эрүү шүүлтийн асуудлаарх Тусгай илтгэгч өөрийн бүрэн эрхийн хүрээнд 2005 оны 6 дугаар сарын 6–9-ний хооронд Монгол Улсад айлчиллаа. Энэхүү айлчлалын үеэр хамтран ажилласан Засгийн газарт талархал илэрхийлж байна. Цаазаар авах ялтай холбоотой мэдээлэл, цаазаар авах ялаар шийтгэгдсэн хүмүүстэй уулзах хүсэлтийг удаа дараа тавьж байсан боловч зөвшөөрөл өгөхөөс татгалзсан нь Тусгай илтгэгчийн ажлын удирдамжийг ноцтой зөрчсөн явдал боллоо.

Энэхүү илтгэлд Монгол Улс дахь эрүүдэн шүүх, хүнлэг бусаар харьцах явдалтай холбоотой хууль, эрх зүйн болон бусад баримт мэдээлэл дээр хийсэн судалгааг оруулсан болно.

Тусгай илтгэгч эрүүдэн шүүх явдал ялангуяа цагдаагийн албадан саатуулах байр болон урьдчилан хорих байранд байсаар байна гэсэн дүгнэлтэд хүрлээ. Түүгээр ч барахгүй цагдан хоригдож байсан этгээд эрүүдэн шүүлтэд өртөн амь насаа алдсан хоёр ч тохиолдол саяхан гарсан байна.

Тусгай илтгэгч “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенц” дахь эрүү шүүлтийн талаарх нэр томъёог Эрүүгийн хуульд нийцүүлж оруулаагүй, эрүү шүүлт тулгасан талаар гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч, мөрдөн шалгах үр дүнтэй механизм байхгүй, эрүү шүүлтийг хориглосон олон улсын хэм хэмжээний талаар суурь ойлголт байхгүй, ялангуяа прокурор, өмгөөлөгч, шүүгч нарын энэ талаарх мэдлэг дутмаг байгаагаас эрүүдэн шүүх, хэрцгий хүнлэг бусаар харьцах явдал байсаар байна гэдгийг тогтоосон. Эцэст нь эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар харьцсаны улмаас хохирогсод шударгаар шүүлгүүлэх, хохирлыг барагдуулах, нэр төрийг сэргээх бололцоо байхгүй байна.

Тусгай илтгэгч жирийн дэглэмтэй хорих 421 дүгээр анги (Амгалан), чанга дэглэмтэй хорих 413 дугаар анги (Зүүнхараа)–ийн нээлттэй, нийтийн зориулалттай шоронгийн нөхцөл байдал нь олон улсын стандартад нийцсэн болохыг тогтоов. Тэрээр Улаанбаатар хот дахь цагдаагийн албадан саатуулах төв байр хэт их хүнтэй байсанд сэтгэл зовниж байгаагаа илэрхийлсэн. Түүнчлэн Цагдан хорих 461 дүгээр анги (Ганц худаг), Зуунмодын урьдчилан хорих байранд сэжигтэн, яллагдагч нарыг цуг хорьсон, камерт байгаа хүмүүсийн тоо хэт их байсанд сэтгэл эмзэглэснээ бас илэрхийлж байна.

Хамгийн их сэтгэл зовнисон зүйл гэвэл 405 дугаар хорих анги (Тахир соёот)–ийн гянданд хоригдож байгаа ялтнуудын нөхцөл байдал юм. Тусгай илтгэгчийн үзэж байгаагаар 30 жил тусгаарлагдмал нөхцөлд ялсныг ял эдлүүлж буй онцгой дэглэм нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 10 дугаар зүйлийг зөрчиж байгаагаас гадна Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцийн эрүү шүүлт биш юм гэж үзэхэд хэрцгий, хүнлэг бусаар хандаж, харьцаж байгаад гарцаагүй тооцож болно.

Тусгай илтгэгч Монгол Улс дахь цаазаар авах ялын асуудлыг тойрсон ялангуяа нууцлалтай холбоотой нөхцөл байдалд гүнээ сэтгэл эмзэглэж байна. Засгийн газрын эрх бүхий албан тушаалтнууд түүнчлэн прокурор, шүүгч нарт удаа дараа хүсэлт гаргасан боловч Тусгай илтгэгчид албан ёсны мэдээллийг гаргаж өгөөгүй. Цаазаар авах тогтоол гүйцэтгэж байгаа газар, огноог хэрэгтний гэр бүлийнхэнд мэдэгддэггүйгээс гадна тэдэнд цогцсыг нь оршуулах боломж өгөхгүй байгаа зэрэг нь хэрэгтний гэр бүлийнхэнд хүнлэг, бусаар хандан, конвенцийн 7 дугаар зүйлийг зөрчиж байна. Цаашилбал, Ганц худаг, Зуунмодын цагдан хорих ангид цаазаар авах ялаар шийтгэгдсэн этгээдүүдийг тусгаарлаж, гав дөнгөтэй, хангалттай хоол хүнсгүйгээр хорьж байна. Эдгээр нөхцөл байдал нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид заасны дагуу эрүү шүүлтэд тооцогдох нэмэлт ял шийтгэлийн шинжтэй байна.

Иймд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар харьцах явдлыг хориглож, урьдчилан сэргийлэх талаарх амлалтаа биелүүлэхэд чиглэсэн дорвитой арга хэмжээ авахыг Засгийн газарт зөвлөж байна.

## МАНФРЭД НОВАКИЙН ТАЙЛАН

*(2005 оны 6 дугаар сарын 6–9-ний өдөр)*

### Танилцуулга

Эрүү шүүлтийн асуудлаарх Тусгай илтгэгч нь 2005 оны 6 дугаар сарын 6–9-ний хооронд Монгол Улсад айлчиллаа. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс 2005 онд Эрүү шүүлтийн талаарх олон нийтийн нээлттэй хяналт шалгалтын ажилд Тусгай илтгэгчийг оролцуулан ажиллуулахыг анхлан санаачилж байсан юм.

Хүний эрхийн зөвлөлийн тусгай үйл ажиллагааг явуулахаар 2004 оны 4 сараас хойш урилга ирүүлээд байсан Засгийн газар Тусгай илтгэгчийг 2005 оны 3 сард Монгол Улсад ирж ажиллахыг урьсан билээ. Айлчлалын хүрээнд Тусгай илтгэгч эрүүдэн шүүх болон хүнлэг бусаар харьцах явдалтай холбоотой хууль эрх зүйн орчин, Засгийн газраас авч байгаа арга хэмжээтэй танилцлаа.

Мөн зөрчил гарсан гэх мэдээллийг Засгийн газрын зүгээс хэрхэн авч үздэг ялангуяа түүнийг шалгах, шийтгэх, урьдчилан сэргийлэх үүднээс авч хэрэгжүүлдэг хариу арга хэмжээг авч судаллаа. Тусгай илтгэгч бичгээр авсан мэдээлэл, төрийн албан хаагчид, Төрийн бус байгууллага, хуульчид, хохирогчид, гэрч нартай хийсэн ярилцлага түүнчлэн хорих газруудад биечлэн очиж хийсэн шалгалтын материалд тулгуурлаж илтгэлээ бэлтгэсэн болно. Үүний дүнд олж тогтоосон зүйлс, дүгнэлт, зөвлөмжөө дараах байдлаар тайлагнаж байна.

1. Тусгай илтгэгчийн айлчлалын гол зорилго нь эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх нөхцөл байдалд үнэлгээ өгөх, тэдгээрийг устгах, урьдчилан сэргийлэх механизмд дэмжлэг үзүүлж, Засгийн газартай тогтоох урт хугацааны хамтын ажиллагааг эхлүүлэхэд оршиж байлаа.

2. Тусгай илтгэгчийг айлчлах үед 2005 оны 5 сард Ерөнхийлөгчийн сонгууль дөнгөж дуусч байсан бөгөөд арав гаруй жилийн өмнө эхлүүлсэн улс төр, эдийн засгийн шинэчлэлтийг бэхжүүлж, төрийн хэт төвлөрсөн тогтолцооноос парламентын ардчилалд шилжих хүнд хүчир замыг туулахын төлөө Монгол Улс нь чармайн ажиллаж байгааг тэмдэглэж байна.

3. Айлчлалын үеэр Тусгай илтгэгч Ерөнхийлөгч Н.Багабандид бараалхаж, Гадаад хэргийн дэд сайд А.Баттөр, Гадаад хэргийн яамны Гэрээ, эрх зүй газрын орлогч захирал О.Очиржав, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Ш.Сүхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Т.Алтангэрэл, тус яамны мэргэжилтэн Ж.Хунан нартай уулзсан юм. Түүнчлэн Ерөнхий Прокурор М.Алтанхуяг, Ерөнхий прокурорын орлогч Б.Цэрэнбалтав, прокурор Т.Сүхбаатар, Дээд шүүхийн ерөнхий шүүгчийн орлогч Д.Батсайхан, Прокурорын байгууллагын дэргэдэх Мөрдөн байцаах албаны дарга Б.Галдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Ж.Чойжанцан, Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах газрын дарга М.Энх-Амгалан нартай уулзлаа.

4. Парисын зарчмын дагуу үүсгэн байгуулагдсан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК)-ын дарга С.Цэрэндорж, гишүүн Ж.Дашдорж, Г.Далайжамц, АА-ны дарга Б.Хишигсайхан, Өргөдөл, гомдол хариуцсан ахлах мэргэжилтэн П.Оюунчимэг, Олон нийттэй харилцах албаны ажилтан Г.Золжаргал, Мэдээлэл харилцааны ажилтан Л.Гэрэл нартай мөн уулзаж ярилцав.

Хүний эрхийн Үндэсний Комисс нь 2005 оныг “Эрүү шүүлтийн асуудлаарх нээлттэй хяналт шалгалтын жил” болгон зарлаж ажлаа 2005 оны 1 дүгээр сараас эхлүүлсэн бөгөөд уг ажил 12 дугаар сард нэгдсэн илтгэл гаргаснаар өндөрлөх юм байна.

Уг ажлын хүрээнд Орхон, Дархан-уул, Төв, Дорнод, Хөвсгөл аймаг болон Улаанбаатар хотыг хамарсан олон талт арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Тухайлбал дотоодын хууль тогтоомжийг олон улсын хэм хэмжээнд нийцэж буй эсэхийг харьцуулан судлах, шүүх, прокурорын байгууллагын ажилтан, өмгөөлөгчид, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулсан зөвлөлдөх уулзалт зохион байгуулах, Улсын прокурорын ерөнхий дэргэдэх Мөрдөн байцаах алба, Цагдаагийн ерөнхий газрын хяналтын алба, болон прокурорын байгууллагад ирсэн өргөдөл, гомдолд дүн шинжилгээ хийх, урьдчилан хорих байр болон хорих ангийн байруудын нөхцөл байдлыг үзэж шалгах, олон нийтэд мэдээлэл сурталчилгаа явуулах, ял шийтгэлгүй үлдсэн байдалд дүн шинжилгээ хийх зэрэг болно. Судалгааны үеэр олж авсан аливаа мэдээллийг олон нийтээр хэлэлцүүлж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацах юм байна. Хүний эрхийн үндэсний байгууллагын санаачилгаар анх удаа хийгдэж буй олон нийтийн нээлттэй хяналт шалгалтын арга хэмжээг Тусгай илтгэгч талархан сайшааж байна. Тусгай илтгэгч эрүү шүүлтийн талаарх ХЭҮК-ын дарга, гишүүд, ажилтнуудын хүчин чармайлтыг өндрөөр үнэлж, цаашид тэднийг тууштай дэмжиж ажиллахаа илэрхийлсэн байна.

5. Тусгай илтгэгч УИХ-ын гишүүн С.Оюун, Л.Гүндалай, Эмнести интернэйшнл, Хүний эрх ба хөгжил төв, Эрх чөлөөний төв, Монголын Эмэгтэй хуульчдын холбоо, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Хоригдлуудын нийгэмлэг зэрэг хэд хэдэн төрийн бус байгууллагын төлөөлөгчид, мөн өмгөөлөгчидтэй уулзжээ.

6. Тусгай илтгэгч дипломат корпусын төлөөлөгчид тухайлбал, Францын Элчин сайд Н.Чапиус, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын Элчин сайд Р.Оостен, АНУ-ын Элчин сайд Памела Служ нартай уулзсан юм. Мөн Монгол дахь НҮБ-ын орон нутгийн ажилтнууд, тухайлбал НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүүхдийн сан, Дүрвэгсдийн дээд комисариатын ажилтнуудтай мөн уулзаж ярилцсан байна.

7. 2005 оны 6 дугаар сарын 7–9-ний өдрүүдэд Тусгай илтгэгч дараах хорих байруудаар орж хоригдож байгаа хүмүүс болон албан хаагчидтай уулзаж ярилцсан юм. Үүнд: Жирийн дэглэмтэй хорих 421 дүгээр анги (Амгалан), Албадан саатуулах газар, Ганц худаг дахь 461 дүгээр цагдан хорих анги, чанга дэглэмтэй хорих 413 дугаар анги (Зүүнхараа), чанга дэглэмтэй хорих 429 дүгээр анги (Тахир соёот), Сүрьеэгийн эмнэлэг, жирийн болон чанга, онцгой дэглэмтэй хорих 405 дугаар анги (Тахир соёот), Цагдан хорих төв (Зуунмод хот) зэрэг болно.

8. Тусгай илтгэгч урилга ирүүлсэн явдалд Монгол Улсын Засгийн газарт талархалаа илэрхийлж байна. Айлчлалын үеэр Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд, Гадаад хэргийн дэд сайд нар бүх талын дэмжлэг үзүүлж хамтран ажилласан байна. Харин шинээр сонгогдсон Ерөнхийлөгч, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гадаад хэргийн сайд нартай уулзаж чадаагүй ажээ.

Засгийн газрын зарим байгууллагуудын зүгээс дэмжлэг туслалцаа үзүүлээгүй явдал нь түүний айлчлалын хүрээн дэх удирдамжийг ноцтойгоор зөрчсөн явдал болов.

Хэдийгээр Тусгай илтгэгчид холбогдох бүх мэдээллийг өгөх, хорих ангийн байранд нэвтрүүлэх, хоригдож байгаа хэнтэй ч уулзаж ярилцах зөвшөөрөл олгохоор тохиролцсон боловч цаазаар авах ялтай холбогдолтой аливаа мэдээлэл болон цаазаар авах ялаар шийтгэгдсэн ялантай уулзах хүсэлтийг удаа дараа тавьсан боловч зөвшөөрсөнгүй. Иймд цаазаар авах ялаар шийтгэх нөхцөл байдалтай холбогдсон асуудлаар гаргасан дүгнэлтийг зөвхөн гэрч, гэр бүлийн гишүүд болон төрийн бус байгууллагаас өгсөн мэдээлэл дээр үндэслэж гаргахаас өөр арга байсангүй.

9. Мөн НҮБ-ын Суурин төлөөлөгч, хатагтай П.Мета, Людвиг Болцманны Хүний эрхийн хүрээлэнгийн хатагтай Е. Мак Артур, Хүний эрхийн дээд комиссариатын газрын Ё.Бэрри, С.Сизд нарт туслалцаа дэмжлэг үзүүлсэн явдалд талархалаа илэрхийлж байна.

## ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

### Олон Улсын түвшинд

10. Монгол Улс нь эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар харьцахыг хориглосон НҮБ-ын хүний эрхийн гол гэрээ, конвенц болох Иргэний болон улсын төрийн тухай олон улсын Пакт, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенц, Хүүхдийн эрхийн Конвенцид нэгдэн орсон. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын нэгдүгээр нэмэлт протоколыг соёрхон баталснаар иргэний болон улсын төрийн эрхийг зөрчсөн тухай иргэний өргөдлийг Хүний эрхийн хороо хүлээн авч хянан үзэх эрхийг (бүрэн эрх) хүлээн зөвшөөрсөн юм. Гэхдээ Эрүүдэн шүүхийн эсрэг

Конвенцийн 22 дугаар зүйлд заасан Эрүүдэн шүүхийн эсрэг хороог хүлээн зөвшөөрөөгүй байна. Түүнчлэн Монгол Улс нь Женевын 1949 оны Конвенц, Олон улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрэм зэрэг холбогдох олон улсын гэрээ хэлэлцээрт нэгдэн оржээ. Монгол Улс нь пактын 2 дахь нэмэлт протоколд нэгдэн ороогүй байна.

### Үндэсний хэмжээнд

а/ Хүний эрхийн Үндсэн хуулийн хамгаалалт

12. 1992 оны Үндсэн хуулийн 10.1–д “олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж 10.2–т “олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэж заасан байдаг. Үндсэн хуулийн 2 дугаар бүлэг нь “Хүний эрх, эрх чөлөө” гэсэн нэртэй бөгөөд 16 дугаар зүйлд “хүний үндсэн эрхүүд, тухайлбал амьд явах эрх, өргөдөл, гомдол гаргах эрх, эрх чөлөөтэй аюулгүй байх эрх, шударга шүүхээр шүүгдэх эрхийн талаар заасан байна. Үндсэн хуульд улс төрийн орогнол хүсэгч болон гадаадын иргэний тодорхой эрхийг тусгасан заалт бий.

13. Үндсэн хуулийн 16.13–т “Хэнд ч боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй” гэж заасан байна.

б/ Эрүүгийн болон процессын хуульд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар, хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийг хориглосон нь

14. 2002 онд шинэчилсэн Эрүүгийн хуулийн 100 дугаар зүйлд эрүүдэн шүүх гэдгийг бие махбодид хүнд, хүндэвтэр гэмтэл учруулахгүйгээр байнга зодох буюу тарчлаах шинжтэй бусад үйлдэл хийсэн эрүүдэн шүүсэн гэмт хэрэг гэж тодорхойлсон байна. Түүнчлэн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, тарчилган зовоох, тохуурхан даажигнах, хуурч мэхлэх зэргээр хууль бус арга хэрэглэж мэдүүлэг өгөхийг албадвал эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байна (251.1 дүгээр зүйл).

15. 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 10.4 дүгээр зүйлд “Хэнд ч боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй” гэж заасан. Мөн Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд “Сэжигтнээс мэдүүлэг өгөхийг шаардах, түүнтэй хүнлэг бус, хэрцгий харьцах, нэр төрийг нь гутаан доромжлохыг хориглоно” гэж заасан байна (81.2 дугаар зүйл).

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай 1999 оны хуулийн 3 дугаар зүйлд “Албадан саатуулагдсан, цагдан хоригдсон этгээдэд эрүү шүүлт тулгах, эсхүл бусад арга хэрэглэн түүний бие махбодыг тарчлаан зовоох буюу сэтгэл санааны дарамтад оруулахыг хориглоно” гэж заасан. Цагдаагийн тухай 1992 оны хуулийн 29 дүгээр зүйлд “Цагдаагийн албан хаагч хууль тогтоомжийг чанд сахиж, хүний эрх, эрх чөлөө, нэр төрийг хүндэтгэн, хүнлэг харилцах үүрэгтэй” гэж заасан.

16. Хэдийгээр “эрүү шүүлтийн” талаар хууль тогтоомжид олон заалт байгаа боловч Монголын хуульд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 1 дүгээр зүйлд заасан “өвтгөн зовоож, хүнд дарамт шахал үзүүлдэг (бие махбод болон сэтгэл санааны хүчтэй шаналал) учруулах”, “аливаа үйлдлийг тодорхой зорилгоор үйлдэх”, “санаатайгаар хийсэн мөн албан тушаалтны санаачилга, зөвшөөрөл эсвэл мэдэж байснаар” гэсэн гол хэсгийг тусгаж өгөөгүй байна.

Түүнээс гадна Эрүүгийн хуульд эрүү шүүлтийн талаарх гол заалт болох 100.1 дүгээр зүйлээр оногдуулах ял шийтгэлийн хэмжээ нь харьцангуй бага буюу 2 жил хүртэл хугацаагаар хорино гэж заасан байна.

17. Конвенцийн агуулгад нийцэхүйц хэд хэдэн үйлдлийг Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцон хуульчилсан бөгөөд дараах ял шийтгэлийг оногдуулж байна. Үүнд: тохуурхан даажигнаж, зовоон тарчлаах замаар бие махбодид санаатайгаар хүнд гэмтэл учруулсан бол (96.2.8 дугаар зүйл) 7–10 жилийн хорих ялаар, хохирогчийг зовоон тарчлааж хөнгөн гэмтэл учруулсан (98.2 дугаар зүйл/) бол 3–5 жилийн хорих ялаар, Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, тарчилган зовоох, тохуурхан даажигнах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэж мэдүүлэг өгөхийг албадсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ялаар (251.1 дүгээр зүйл) эсхүл энэ хэргийн улмаас хүний бие махбодид хүндэвтэр, хүнд гэмтэл учирсан бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ялаар, санамсаргүйгээр бусдын амийг хөнөөсөн (94 дүгээр зүйл) бол дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ялаар, харгис, хэрцгий харьцсан буюу байнга гутаан доромжилсны улмаас хохирогч амиа хорлосон (95 дугаар зүйл) бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ялаар, бусдын бие махбодид хүнд гэмтэл болгоомжгүйгээр учруулсан (97 дугаар зүйл) бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих ялаар, бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатай учруулсан бол (99 дүгээр зүйл) гурваас зургаан сар хүртэл хугацаагаар хорих ялаар, өвчтөнд эмнэлгийн тусламж үзүүлээгүй бол (106 дугаар зүйл) гурваас зургаан сар хүртэл хугацаагаар хорих ялаар, бусдыг амь насанд нь аюултай нөхцөлд байхад нь яаралтай тусламж үзүүлээгүй бол (107 дугаар зүйл) гурваас таван жил хүртэл хугацаагаар хорих ялаар, төрийн албан тушаалтан албан үүргийн хувьд хуулиар олгогдсон эрх мэдлээ хэтрүүлснээс үлэмж хэмжээний хохирол учирсан бол (264.2 дугаар зүйл) таван жил хүртэл хугацаагаар хорих ялаар, албан тушаалтан албан үүргээ биелүүлээгүйн улмаас хүнд хор уршиг учирсан бол 3 жил хүртэл хорих ялаар тус тус шийтгэнэ гэж заасан байна.

18. Эрүү шүүлтийн талаарх захиргааны хариуцлагын тухайд цалингаас хасах, тушаал бууруулах, ажлаас халах зэрэг захиргааны хариуцлага тооцдог цагдаагийн сахилгын хороо байдаг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад бас хорих байгууллагын ажилтанд ийм төрлийн арга хэмжээ авдаг байна.

в) Баривчлах, цагдан хорих үед эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бус харьцахаас хамгаалах нь

19. Баривчлах, цагдан хорихтой холбогдсон хууль гэж Үндсэн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай” болон Цагдаагийн тухай хууль (1993 он)–ийг үзэж болно.

### **Баривчлах, урьдчилан хорих болон мөрдөн байцаах**

20. Баривчлагдсан, цагдан хоригдож буй этгээдийг хамгаалах Үндсэн хуулийн хамгаалалтын асуудлаар 16 дугаар зүйлд баривчилсан шалтгаан, үндэслэлийн талаар баривчлагдсан этгээд, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэх (16.13 дугаар зүйл), өөрийгөө өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах (16.14 дүгээр зүйл) эрхийн талаар заасан байна.

21. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд сэжигтэнг баривчлах үеийн эрх хэмжээг тогтоосон байна. Хуулийн 35.2 дугаар зүйлийн дагуу сэжигтэн этгээд дараах эрхтэй байна. Үүнд ямар хэрэгт сэрдэгдэж байгаага мэдэх өөртэй нь холбогдуулж эрүүгийн хэрэг үүсгэсэн, баривчилсан тогтоолтой танилцах, өөрийгөө өмгөөлүүлэх, өмгөөлөгч авах, өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах зэрэг болно.

22. Монгол Улсад хүний эрх, эрх чөлөөг олон байгууллага хаа сайгүй хязгаарлах бололцоотой. Тухайлбал Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар, Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний Тагнуулын Ерөнхий газар, Батлан хамгаалах, Эрүүл мэндийн яамны харьяа газрууд үүнд багтаж байна.

Ерөнхийдөө, хорих газруудыг түр саатуулах байр (72 цаг хүртэл) урьдчилан хорих байр (30 сар хүртэл) жирийн болон чанга дэглэмтэй, урт хугацааны (6 буюу түүнээс дээш хугацаагаар) ял эдлэх хорих ангиуд, гол төлөв захиргааны шинжтэй арга хэмжээг авч эдлүүлэх зорилготой (эрүүлжүүлэх байр) тусгаарласан төвүүд гэж ангилж болно. Хорих эрх үүрэг гүйцэтгэдэг (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар), мөрдөн байцаах ажиллагаа явуулах (Цагдаагийн ерөнхий газар) байгууллагууд нь нэг яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарч байгаа бөгөөд ижил төрлийн тухайлбал цагдаагийн түр саатуулах байр болон урьдчилан хорих байр (Ганц худаг дахь 461 дүгээр анги), хорих анги (тусгай дэглэмтэй цаазаар авах ялтанг байлгадаг шоронг хүртэл) –ийг нийтэд нь удирддаг байна.

23. Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд урьдчилан хорих хугацааг заасан байдаг. Хуулийн 59.5, 59.6 дугаар зүйлд заасны дагуу шүүх цагдан хорих зөвшөөрөл олгох эсхүл суллах шийдвэр гаргахаас өмнө сэжигтнийг 72 цаг хүртэл хугацаагаар саатуулах боломжтой (өөрөөр хэлбэл цагдаагийн ажилтан баривчлах тогтоол авахаас өмнө 24 цаг саатуулж болох бөгөөд шүүгчээс тогтоол авснаас 48 цагийн дотор цагдан хорих эсхүл суллах үүрэгтэй) 72 цагийн дараа шүүхийн шийдвэр гараагүй бол шууд суллах үүрэгтэй. 61 дүгээр зүйлд заасны дагуу саатуулагдсан этгээдийн гэр бүлийнхэн болон өмгөөлөгчид 24 цагийн дотор саатуулсан болон баривчилсан тухай мэдэгдэх ёстой.

24. “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай 1999 оны хуулийн 6.4 дүгээр зүйлд “Төв, суурин газраас алслагдсан нутаг дэвсгэрт байгаа цэргийн анги, салбарын сахилгын хорих байранд сэжигтнээр 14 хоног хүртэл хугацаагаар цагдан хорьж болно”; Цагдаагийн тухай 1993 оны хуулийн 24.3 дугаар зүйлд “Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэг, захиргааны зөрчил үйлдсэнд сэрдэгдсэн этгээдийн нэр, хаягийг тодруулах, албадан саатуулах үндэслэл байгаа эсэхийг тогтоохын тулд уул этгээдийг 6 цаг хүртэл хугацаагаар түр саатуулж болно”; Захиргааны хариуцлагын тухай 1992 оны хуулийн 13 дугаар зүйлд “Зөрчлийг таслан зогсоох, зөрчлийн тухай тэмдэглэл үйлдэх үед шаардлагатай гэж үзвэл зөрчил гаргасан этгээдийг сумын Засаг дарга, цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан, хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах захиргааны журмаар албадан саатуулж болно. Зөрчил гаргасан этгээдийг захиргааны журмаар түр саатуулах хугацаа 6 цагаас илүү байж болохгүй; Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай 1994 оны хуулийн 1 дүгээр зүйлд “Хараа хяналтгүйгээс амь нас, эрүүл мэнд нь хохирч болзошгүй 16 хүртэлх насны, хаяг, эцэг эх,

харгалзан дэмжигч нь тодорхойгүй хүүхдийг цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан 7 хоног хүртэл хугацаагаар түр саатуулж болно”; Тагнуулын байгууллагын тухай 1999 оны хуулийн 12.1.5 дугаар зүйлд “Тагнуулын ерөнхий газарт хуулиар харьяалуулсан гэмт хэргийн сэжиг бүхий этгээдийг түр албадан саатуулах, шалгах”; Хилийн тухай 1993 оны хуулийн 33 дугаар зүйлд “Хэрэг бүртгэх эрх бүхий албан тушаалтан нь улсын хилийн болон хил орчмын дэглэм зөрчсөн этгээдийг тэмдэглэл үйлдэх зорилгоор гурван цаг хүртэл албадан саатуулж болно” гэж тус тус заасан байна.

Үүнээс үзэхэд хэд хэдэн байгууллагын албан хаагчид өөрсдийн эрх мэдлийн хүрээнд иргэдийг 3–72 цаг хүртэл хугацаагаар барьж саатуулах эрхтэй байгаагаас гадна Тагнуулын байгууллагын тухай хуульд заасны дагуу тагнуулын ажилтан тодорхой бус хугацаагаар саатуулах эрхтэй байна.

25. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 41.3.1 дүгээр зүйлд “өмгөөлөгчийг байлцуулах эрхтэй”, 35.2.5 дугаар зүйлд “хэлмэрч авах эрхтэй”–г заасан байна. 79.4 дүгээр зүйлд “Нотлох баримт цуглуулах, баримтжуулах талаар хуульд заасан журмыг баримтлаагүй буюу зөрчсөн бол эдгээр нь нотлох чадвараа алдах бөгөөд шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй” гэж заасан байна.

### **Урьдчилан хорих**

26. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 36.3 дугаар зүйлээр “Яллагдагчид сэжигтэнтэй төстэй хамгаалалтыг олгосон байна. Таслан сэргийлэх арга хэмжээнд оршин суугаа газраасаа гадагш явахгүй тухай баталгаа авах, батлан даалтад өгөх, эд хөрөнгө барьцаалах, цагдан хорих зэрэг багтана (62 дугаар зүйл).

27. 68 дугаар зүйлд хүнд, онц хүнд хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, түүнчлэн удаа дараа ял шийтгэгдэж байсан этгээд, онц аюултай гэмт хэрэгтэн дахин гэмт хэрэгт сэрдэгдсэн бол түүнийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлах, хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулах, гэмт хэрэг дахин үйлдэхээс сэрэмжлэх зорилгоор цагдан хорьж болно. Хүндэвтэр гэмт хэргийн оролцогч этгээдийг өмнө нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, оргон зайлж болзошгүй бол цагдан хорьж болно.

28. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 69.1–4 дүгээр зүйлд цагдан хорьж мөрдөх хугацааг 14 – 30 сар хүртэл байхаар заасан. 18 насанд хүрээгүй сэжигтнийг 18 сар хүртэл хугацаагаар цагдан хорьж болно (366.4 дүгээр зүйл).

29. Тусгай илтгэгч нь цагдан хорих дээд хугацаа хэт урт байгаа, практикт цагдан хорих явдал ердийн жишиг болгон хэрэглэж байгаа болон цагдан хорих, хорих ялнаас онцын ялгаатай зүйл алга байна. Сэжигтэнг ялантай цуг байлгаж болохоор байна гэдгийг цохон тэмдэглэжээ. Тусгай илтгэгч урьдчилан хорихын энэхүү байдал нь олон улсын эрх зүйн (Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 9 дүгээр зүйлийн 3 дугаар хэсэг) гэм буруугүйг нотлох зарчим болон эрх чөлөөг хязгаарлах тусгай журамтай зөрчилдөж байна. Хүүхдийн эрхийн хороо нь хүүхдийг урт хугацаагаар цагдан хорьж байгаа практик ажиллагаа, хөнгөн төрлийн гэмт хэрэг анх удаа үйлдсэн хүүхдэд хорих ял оногдуулж байгаа байдал, хүүхдэд оногдуулсан хорих ялыг хойшлуулахад хүндрэл учирч байгаа зэрэгт сэтгэл гүнээ зовниж байгаагаа илэрхийлсэн байна.



### **Ялтныг хорих**

30. Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлд “Хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн эрэгтэй ялтан, түүнчлэн онц хүнд гэмт хэрэгт ял шийтгэгдсэнээс болон онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсоноос бусад эмэгтэй ялтны хорих ялыг жирийн дэглэмтэй хорих ангид, хүнд гэмт хэрэг үйлдсэн, эсхүл урьд нь хорих ял эдэлж байсан эрэгтэй ялтан, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эмэгтэй ялтны хорих ялыг чанга дэглэмтэй хорих ангид, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн буюу онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эрэгтэй ялтны хорих ялыг онцгой дэглэмтэй хорих ангид тус тус эдлүүлнэ” гэж заасан. 53 дугаар зүйлд “Ерөнхийлөгч цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн амийг уучилсан тохиолдолд гучин жилийн хугацаагаар гянданд хорих ялаар солино” гэж заасан байх бөгөөд эдгээр хүмүүс хорих 405 дугаар ангид ганцаарчлан тусгаарлагдан ялаа эдэлж байна.

### **Хорих ангид очсон талаар**

31. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай 1999 оны хуулийн 45 дугаар зүйлд ганцхан цагдан хорих байранд хяналт шинжилгээ хийх тухай заасан байна. Үүнд цагдан хорих байрны үйл ажиллагаа, нөхцөл, журам нь энэ хуульд хэрхэн нийцэж байгаад прокурорууд хяналт тавина гэж заасан. Системтэйгээр хараат бус хяналт шалгалтын талаар заалт алга. Хэдийгээр Хүний эрхийн Үндэсний Комисс аливаа хязгаарлалтгүйгээр шууд нэвтрэн орох эрхтэй боловч төрийн бус байгууллагуудын эрх хязгаарлагдмал байгаа бөгөөд зөвшөөрлийг хааяа олгодог байна.

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэж байгаа байдалд хийсэн шалгалт

### **Гомдол болон мөрдөн байцаалт**

32. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 20, 35.2, 36.3 болон 106 дугаар зүйлд Сэжигтэн, яллагдагч нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн үйл ажиллагаа, цагдан хорих байрны үйл ажиллагааны талаар гомдол гаргаж болно. Шинэхэн байгуулагдсан Прокурорын байгууллагын дэргэдэх Мөрдөн байцаах алба нь цагдаа, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн үйлдсэн гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулна (ЭБШХ-ийн 27.2 дугаар зүйл, Прокурорын байгууллагын 2002 оны хуулийн 10 дугаар зүйл).

33. Эрүүгийн хуулийн 70 дугаар зүйлд хөнгөн гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн, хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш хорин жил өнгөрсөн, онц хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш гучин жил өнгөрсөн бол эрүүгийн хариуцлагад татахгүй.

34. Хүний эрхийн Үндэсний Комиссын 2000 оны хуулийн 9 дүгээр зүйлд “Хүний эрхийн Үндэсний Комисст гомдол гаргаж болно” гэж заасан. Уг хуулиар Комисст хүмүүсийг дуудан ирүүлэх, хорих байранд чөлөөтэй нэвтрэх, баримт материал авах, шинжээч томилох зэрэг эрхийг олгожээ. Мөн Комисст шүүхэд нэхэмжлэл гаргаж, шүүх хуралдаанд оролцох эрхийг энэ хуулиар олгосон байна. Энэ хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комисст гомдол гаргагч нь гомдлыг эрх нь

зөрчигдсэн өдрөөс эсхүл тийнхүү зөрчигдсэн тухайгаа мэдсэнээс хойш 1 жилийн дотор гаргах ёстой.

### **Нөхөн олговор**

34. Үндсэн хуульд бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхийн тухай заажээ (16.4 дүгээр зүйл). Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 35.2, 36.3 дугаар зүйлд төрийн албан хаагчийн хууль бус үйл ажиллагаанаас учруулсан хохирлыг төлүүлэх эрхийн тухай заасан. 44 дүгээр бүлэгт (388–397 дугаар зүйл) уг эрхийн асуудлыг нарийвчлан зохицуулсан байна. Гэхдээ, нөхөн олговор олгох үндэслэлд (389 дүгээр зүйл) хууль бусаар баривчлах, яллах, хорих гэж заасан байх бөгөөд эрүүдэн шүүх, хүнлэг бусаар харьцах талаар заагаагүй байна.

## **II. ЭРҮҮ ШҮҮЛТИЙН ТАЛААРХ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ**

36. Өнгөрсөн хугацаанд Тусгай илтгэгч нь Монгол Улс дахь эрүүдэн шүүх, хүнлэг бус харьцах талаар хэд хэдэн гомдол, мэдээлэл хүлээн авсан. Гэхдээ урд дурдсанчлан эрүү шүүлт гарч байгаа талаар ирсэн гомдлын тоо нь тус улсад эрүүдэн шүүлт түгээмэл байна гэсэн үг биш. Харин ч хувь хүмүүс, өмгөөлөгчид, иргэний нийгэм эрүү шүүлт гэж юу болох, түүнчлэн гомдол мэдээлэлд хариу арга хэмжээ авдаг олон улсын механизмын талаарх олон нийтийн мэдээлэл, сурталчилгааны түвшинг илтгэх үзүүлэлт байж болох юм. Тусгай илтгэгчийн үзэж байгаагаар олон нийтийн дундах эрүү шүүлтийн талаарх ойлголт хомс, гэмт хэргийн сэжигтэн этгээдүүдийн эсрэг тодорхой хүч хэрэглэхийг хүлээн зөвшөөрсөн зан үйлийн хандлага байгаа нь харагдсан. Энэ нь яллахын тулд сэжигтэн яллагдагчийн гэм бурууг нь хүлээлгэхийг зорьдог эрүүгийн эрх зүйн тогтолцоо давамгайлсан байдалтай хавсраад эрүү шүүлтийг бодит практик болгох эрсдлийг бий болгож байна.

37. Хоригдож байгаа этгээдүүдтэй хийсэн уулзалт ярилцлага, болон айлчлалын үеэр ирсэн гомдол мэдээлэл (зарим хэсгийг хавсралтад байгаа), түүнчлэн төрийн зарим өндөр албан тушаалтан, Хүний эрхийн Үндэсний Комисс, өмгөөлөгч нартай уулзсан уулзалт, төрийн бус байгууллагаас авсан мэдээ, хөндлөнгийн шүүх эмнэлгээс гаргасан нотлох баримтад үндэслэн Тусгай илтгэгч хууль сахиулах байгууллагын албан хаагчаас эрүүдэн шүүх, хүнлэг бусаар харьцах явдал ялангуяа цагдаагийн албадан саатуулах байр, урьдчилан хорих байр, чанга, онцгой дэглэмтэй хорих анги (тухайлбал цаазаар авах ялаар шийтгэгдсэн хүмүүс)–д оршин байна гэсэн дүгнэлтийг хийж байна.

38. Ихэнх хэргүүдэд хэрэглэсэн эрүүдэн шүүх нийтлэг арга нь хэрэг хүлээлгэхийн тулд шанаадах, бороохойдон зоддог болохыг тусгай илтгэгч олж тогтоосон юм. Тусгай илтгэгч Монголд ирэхийн өмнөхөн Мөнхбаярын Баатар нь (хэргийн тухай хавсралтад дурдсан) урьдчилан хорих байранд хэрцгийгээр зодуулж гэмтлийн улмаас амь насаа алдсан тухай мэдээллийг тэрээр авч байсан. Өөр хэрэглэдэг аргын төрөлд нь “агаарт нисгэх”, (сандал дээр зогсоож байгаад сандлыг нь түлхэж унагаах), хурууны хумсны завсраар зүү шаах, цахилгаан гүйдэлд цохиулах (өрөөний таазны гэрэлд холбосон цахилгааны утсыг хувинтай усанд хийх замаар) тамхины цогоор түлэх, удаан хугацаагаар

гав, дөнгөтэй байлгах (тасралтгүй 3 жилийн турш гавтай байлгасан тохиолдол бий), харуулаас хүчирхийлэх дэмжлэг авсан гэмт этгээдийн өрөөнд сэжигтнийг цуг хорьж, хүч хэрэглэн хэрэг хүлээлгэх, өмгөөлөгч, гэр бүлийн хүмүүсээс зайтай байлгах зорилгоор газар зүйн хувьд алслагдмал орших цагдан хорих байранд сэжигтнийг хорих зэрэг орно. Хоригдогчийн аюулгүй байдлыг хангах явдлыг (дээрх 20 дугаар хэсэг) тухайлбал өмгөөлөгч, гэр бүлийн гишүүдэд мэдэгдэх зэргийг удаа дараа үл хайхрах явдал гарсаар байна.

### **Мөрдөн байцаалтыг дутмаг явуулах болон ял шийтгэлгүй үлдэх байдал**

39. Тусгай илтгэгчийн үзэж байгаагаар ял шийтгэлгүй үлдэх байдал нь эрүүдэн шүүх, хүнлэг хэрцгий байдлаар харьцах явдал оршиж байгаагийн гол шалтгаан бөгөөд тодорхой чиглэсэн үр дүнтэй арга хэмжээ авахгүй бол цаашид Монголд ял шийтгэлгүй үлдэх хэв маягийг улам даамжруулах болно. Эрүүгийн хуульд эрүү шүүлтийн нэр томъёог конвенцтэй нийцүүлэн тодорхойлоогүй, гомдлыг хүлээн авч мөрдөн шалгах ядмаг тогтолцоо оршиж байгаа нь гэмт этгээдүүдийг халхавчилж байна. Хэдийгээр ийм тодорхойлолт байхгүй ч гэсэн уг зүйл заалтаар одоо болтол хууль сахиулах байгууллагын нэг ч ажилтанд прокуророос ял тулгаж шийтгээгүй байгаа нь гэм буруугаас зайлсхийж байгааг тодорхой харуулж байна.

40. Тусгай илтгэгч хохирогч, хууль сахиулах байгууллагын албан хаагчид, прокурор, өмгөөлөгч, шүүхийн байгууллагын хүмүүстэй уулзаж ярилцаж байхад эрүү шүүлтийг хориглох явдалтай холбоотой олон улсын стандартын талаарх ойлголт, сурталчилгаа дутмаг болох нь ажиглагдаж байсан. Хүний эрхийн Үндэсний Комиссоос санаачлан явуулсан олон нийтийн нээлттэй хяналт шалгалтаас өөр засгийн газрын зүгээс Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн талаарх сурталчилгааг олон нийт, хууль хяналтын байгууллага, хуулийн мэргэжилтэн, шүүхийн албан хаагчдын дунд явуулаагүй байна. Цагдаагийн академийн сургалтын хөтөлбөрт хүний эрхийн сэдвээр 2 өдрийн хичээл оруулахаар тохиролцсон боловч одоогийн байгаа бие бүрэлдэхүүний дөрөвний гурав нь хүний эрхийн тухай сургалтад хамрагдаагүй тухай мэдээ байна.

41. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуульд хохирогч гомдол гаргаж шийдвэрлүүлэх талаар заалт байгаа бөгөөд энэ нь практикт хэрэгжихгүй байна.

Хэдийгээр Прокурорын байгууллагын дэргэд Мөрдөн байцаах албыг байгуулан ажиллуулж байгаа боловч энэ байгууллага нь өөрийн үйл ажиллагааг үр дүнтэй явуулах чадавхгүй байна. Тусгай илтгэгч 2005 оны 6 дугаар сарын 6-ны өдөр Мөрдөн байцаах албаны дарга Б.Галдаатай уулзаж ярилцсан бөгөөд тэрээр үйл ажиллагаа дутагдалтай явагдаж байгаа тухай дурдсан байна. Тухайлбал ажлын байр дутмаг, тоног төхөөрөмж хангалтгүй, байгууллагын 24 ажилтны 80 хувь нь дөнгөж сургууль төгссөн мөрдөн шалгах туршлагагүй хүмүүс байна. Цашилбал Мөрдөн байцаах алба нь хэргийг зөвхөн прокуророос шилжүүлсэн тохиолдолд шалгаж байгаа бөгөөд өөрсдөө санаачлан мөрдөн байцаах ажиллагаа явуулах боломжгүй юм. Тусгай илтгэгч гаргасан гомдлыг нь барагдуулна гэдэгт итгэл муутай байдаг болохоор хохирогч хариу өшөө авалтаас эмээж гомдол бараг гаргадаггүй болохыг ажигласан байна.

42. Дээр дурдсан зүйлүүдээс харахад эрүүдэн шүүгдэж, хүнлэг бусаар хандах

явдалд өртсөн хохирогчийг хамгаалсан эрх зүйн хамгаалалт түүнчлэн хохирлыг нөхөн олгох болон сэтгэл зүйн хохирлыг нөхөн сэргээх байдал хангалтгүй, үр дүнгүй байна.

### III. ХОРИХ БАЙРНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ

43. Тусгай илтгэгч жирийн дэглэмтэй 421 дүгээр хорих анги (Амгалан), чанга дэглэмтэй хорих 413 дугаар хорих анги (Зүүнхараа) –ийн байранд очиход нөхцөл байдал нь олон улсын стандартад ерөнхийдөө нийцсэн байлаа. Эдгээр анги нь нээлттэй, нийтийн байрны хэлбэртэй байртай байсан бөгөөд харьцангуй сайн зохион байгуулагдсан байсан бөгөөд тусгай илтгэгч тэнд хүнлэг бусаар харьцсан тухай аливаа гомдол, мэдээллийг ял эдэлж байгаа хоригдлуудаас хүлээн аваагүй байна.

44. Улаанбаатар хот дахь цагдаагийн саатуулах байранд очсон өдөр 97 хүн хүлээн авах багтаамжтай байранд 7–30 хоног баривчлах ялтай 217 хүн байсан бөгөөд 72 цаг саатуулах байранд 48 хүн байлаа. Хоригдож байгаа хүмүүсийн тапаас илүү хувийг газар унтуулж байлаа. Төвийн дарга Б.Очирбатын ярьж байснаар 8х6 м хэмжээтэй уулзалтын нэг өрөөг 100 гаруй хүнд унтуулах газар болгон хэрэглэж байлаа. Оройн цагаар унтах дэвсгэр хөнжлийг өгдөг бөгөөд өрөө нь хүйтэн, халаалт байхгүй байсан. 8–10 хүн хүлээн авах багтаамжтай 8 камер байсан бөгөөд тэдгээрийн нэг нь эмэгтэйчүүдийн камер байсан юм. Бие засах суултуур, угаалтуур зэрэг нь муу нөхцөлтэй байсан хэдий ч байр нь харьцангуй цэвэрхэн байлаа. Хүнлэг бусаар харьцсан тухай мэдээлэл байхгүй байсан боловч ихэнх нь хэт их хүнтэй ялангуяа унтах болоцоо муу, оройн 7–11 цагийн хооронд задгай талбайд чимээгүй байхаас өөр ямар ч хийх ажилгүй нэг л хэвийн өдрийн хуваарьтай байна гэсэн гомдол гарчээ.

45. 461 дүгээр цагдан хорих анги (Ганц худаг), цагдан хорих байр (Зуунмод)–д тусгай илтгэгч камерт хоригдож байгаа хүмүүсийн тоо хэт их байгаад сэтгэл зовниж байгаан дээр сэжигтэн яллагдагчийг цуг хорьж байгаа нь конвенцийн 10.2 (а)–г зөрчиж байна.

46. Гэхдээ тусгай илтгэгчийн хамгийн их сэтгэл зовниж байгаа асуудал бол 405 дугаар хорих анги дахь гяндан (Тахир соёот), цагдан хорих байранд тухайлбал Ганц худаг, Зуунмодод цаазаар авах ялыг гүйцэтгэхийг хүлээж байгаа ялтны нөхцөл байдал юм.

#### **Урт хугацааны хорих ялтай хоригдлуудад зориулсан онцгой дэглэм**

47. Тусгай илтгэгч 405 дугаар хорих ангид 2005 оны 6 дугаар сарын 8–ны өдөр очсон байна. Энэ нь тус улс дахь ялтныг зөвхөн камерт нь байлгах зориулалт бүхий байр юм. Очсон өдрийн байдлаар 64 ялтан байсан бөгөөд тэдгээрийн 55 нь 2–5 жилийн хорих ялтай байсан бөгөөд 9 нь 30 жилийн хорих ялыг ганцаарчилсан байдалд эдэлж байна. Тэдгээр нь урьд нь цаазаар авах ялаар шийтгэгдсэн хүмүүс байлаа. Ганцаарчлан хоригдож байгаа ялтнууд хоёр давхарын залгаа 9 камерт байсан. Камер тус бүр нь бие засах суултуур, угаалтуур, нэг ор, шалтай бэхэлсэн жижиг ширээ, радиатор, таазан дээр нээлтэй 30смХ2м хэмжээтэй цонх бүхий 3х3 талбайтай. Камер бүр нь хаалга болон төмөр сараалжин хаалгатай. Ялтнуудыг дээд тал нь долоон хоногт 2 удаа нэг цагаар

гаргадаг ба энэ нь хүйтэн үед богинохон хандлагатай байдаг тухай өөрсдөө ярьж байсан. Тэдэнд жилд 2 удаа эргэлт авахыг хүлээн зөвшөөрдөг бөгөөд эргэлт бүр нь хэдхэн цаг үргэлжилдэг байна. Тэднийг гадагшаа гаргахдаа гарыг нь гавладаг бөгөөд эргэлтийн үед мөн гавлаж, дөнгөлдөг байна. Ялангуяа 30 жилийн хорих ялаар шийтгэгдсэн эдгээр хүмүүсийг 24 цагийн турш камерт нь чөлөөт цаг өнгөрөөх, боловсрол олох зэрэг сургалт хүмүүжлийн ажиллагаа явуулахгүйгээр хорьдог байна. Камер тус бүрийн гадна талд суурилуулсан 9 телевизорыг оройн 6–11 цагийн хооронд үзүүлдэг байна. Тэд унших материал авч болно. Тусгай илтгэгч ганцаарчилан хоригдож байгаа 9 ялантай уулзаж ярилцсан бөгөөд цуглуулсан мэдээлэл нь ялтнуудын ярьж байгаатай нийцэж байсан юм. Тэнд хөлөндөө шаардлагатай эмчилгээ авч чадаагүй учраас ирснээсээ хойш тэргэнцэртэй байгаа нэг хүнээс өөр яаралтай эмнэлгийн тусламж авах гомдолтой хүн байсангүй. Хэдийгээр өмнө нь зоддог байсан тухай ноцтой мэдээлэл тусгай илтгэгчид хэд хэд ирж байсан боловч харуул хамгаалалтын хүмүүсийн хүнлэг бусаар харьцаж байгаа тухай мэдээлэл байхгүй байсан. Очих үед хийх ажилгүй хоригдож байгаа хүмүүс илт гутрангуй, цөхөрсөн, амиа хорлох бодол төрдөг тухайгаа илэрхийлж байсан, зарим нь ингэж тусгаарлагдмал байснаас цаазаар авах ялаар шийтгүүлсэн нь дээр гэж ярьж байлаа.

48. Тусгай илтгэгчийн үзэж байгаагаар тусгаарлан хорих онцгой дэглэмийн талаарх ойлголт (бодлого) нь ялтныг засан хүмүүжүүлэх, дахин нийгэмшүүлэхэд чиглэсэн конвенцийн 10 дугаар зүйлийн 3 дугаар хэсэгтэй зөрчилдөж байна. Тэдэнд ногдуулж буй ял шийтгэл нь тодорхой хугацаагаар хязгаарлагддаг бөгөөд тэдгээрийг хожим суллагдахад засан хүмүүжүүлэх, дахин нийгэмшихтэй холбоотой асуудлыг авч үзээгүй байна. Ялтныг байнга тусгаар байлгах нь аюулгүй байдлын шалтгаантай гэж санагдахгүйгээр үл барам байгаа фактыг авч үзэхэд тусгаарлахын зорилго нь нэмэлт ял шийтгэл ногдуулж, хүнд зовлон шаналалд хүргэх шалтгаан болж байгаа нь харагдаж байна. Иймд тусгай илтгэгч энэ дэглэм нь эрүүдэн шүүх бус ч “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц”-ийн 1 дүгээр зүйлд заасан хэрцгий, хүнлэг бусаар харьцах явдал гэж дүгнэн үзэж байна.

49. Гянданд хоригдож байгаа ялтнуудтай холбогдуулан тусгай илтгэгч Иргэний болон улсын төрийн эрхийн тухай олон улсын пактын 10 дугаар зүйлийг хангахаар авсан арга хэмжээ, түүнчлэн олон улсын стандарт тухайлбал ялтанд үзүүлэх наад захын стандарт хэм хэмжээний талаар мэдээлэл хүссэн юм. 2005 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн албан захидалдаа Засгийн газар 2005 оны 8 дугаар сарын байдлаар Хорих 405 дугаар ангид 69 ялан ял эдэлж байгаа бөгөөд тэдгээрийн 9 нь 30 жилийн хорих ялтай, бусад нь 3–5 жилийн хорих ялтай байгаа тухай мэдэгджээ. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2002 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 215 тоот тушаалаар баталсан Хорих ангийн дотоод журмын дагуу эдгээр 9 ялан байгалийн гэрэлтэй 9м<sup>83</sup> талбай бүхий тусгаарласан өрөөнд байрлаж байна. Ялтнуудад шүд, нүд, зүрх судасны болон бусад төрлийн эмчийн үзлэг хийх зэргээр эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг. Мөн төрийн бус байгууллагуудын туслалцаатайгаар сэтгэл зүйн дэмжлэг үзүүлдэг. Тухайлбал урт хугацааны хорих ялтай ялтанд төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр сар бүр 20 ам.долларын тэтгэмж олгож Монголын хорих байгууллагын нийгэмлэг (ТББ)-ын дэмжлэгтэйгээр англи, франц хэлний сургалтыг бас

зохион байгуулдаг. Хорих байрны үйл ажиллагааг хорих байрны дотоод журмын дагуу зохион байгуулж, ялтнаас гаргасан өргөдөл, гомдлыг холбогдох байгуулагад шилжүүлж шийдвэрлүүлдэг. Ялтныг ерөөнд нь гавладаггүй боловч гэр бүлийн хүмүүстэй нь уулзуулах болон салхинд гаргах үедээ Хорих байрны дотоод журмын дагуу гавладаг.

### **Цаазаар авах ялаар шийтгэгдсэн ялтан**

50. Тусгай илтгэгч Монгол Улс дахь цаазаар авах ялыг тойрсон бүх нөхцөл байдал ялангуяа төрийн нууц гэж үзэж байгаа явдалд гүнээ сэтгэл зовниж байна. Ялыг гүйцэтгэх тоо нэмэгдэж байгаа гэсэн мэдээлэл байгаа бөгөөд одоогийн байдлаар жилд 20–30 орчим хүн байгаа гэхдээ энэ нь албан бус статистик мэдээ юм. Ерөнхийлөгч, прокурор, шүүхийн дээд албан тушаалын хүмүүст удаа дараа хүсэлт гаргасан боловч Тусгай илтгэгчид цаазаар авах ялаар шийтгэгдсэн, уучлагдсан, гүйцэтгэгдсэн хүмүүсийн тоо, нэр, албан ёсны мэдээлэл болон гүйцэтгэх цаг хугацаа, газрын талаарх мэдээллийг өгөөгүй юм. Цаазаар авах ялаар шийтгэгдсэн хүний гэр бүлийн нэг гишүүнийг ялантай нэг удаа уулзахыг зөвшөөрдөг ч гэр бүлийнхэнд нь ялыг гүйцэтгэх огноо, газрыг мэдэгддэггүй бөгөөд гүйцэтгэгдсэн цогцсыг оршуулахаар хүлээн авдаггүй байна. Ляшкевичийн Беларусын эсрэг хэрэгт Хүний эрхийн хороо “ялыг гүйцэтгэх огноог тойрсон бүхий л нууцлал, оршуулах газар, цогцсыг оршуулахаар өгөхөөс татгалзаж гэр бүлийн гишүүдийг санаатайгаар тодорхой бус байдалд үлдээн, сэтгэл зүйн дарамтад оруулах замаар айлган сүрдүүлж, шийтгэхэд хүргэж байгаа .... нь (гэр бүлийн гишүүдэд) хүнлэг бусаар хандаж байна” энэ нь конвенцийн 7 дугаар зүйлийг зөрчиж байна гэж үзжээ. Тусгай илтгэгчийн зүгээс Монгол Улсад мөн ийм үнэлгээг өгч байна.

51. Тусгай илтгэгч цаазаар авах ялаар шийтгэгдсэн хүмүүсийг тусгаарлан, байнгын гав, дөнгөтэйгээр цагдан хорих байранд хорих, хангалттай хоол хүнс өгөхгүй байгаа тухай ноцтой мэдээллийг хүлээн авсан юм. Цаашилбал тэрээр Ганц худаг, Зуунмод дахь цагдан хорих байранд цаазаар авах ялаар шийтгэгдэн хоригдож байгаа хүмүүстэй тухайлбал Ганц худаг, Зуунмодын цагдан хорих байранд тус тусдаа хоригдож байгаа Баяржав, Сэдэдийн Батаа нарын талаар тодорхой, нарийвчилсан мэдээллийг олж авсан юм (хэргүүдийг хавсаргасан). Цагдан хорих бүх байруудад саадгүй нэвтрэн орох бүрэн эрхийг Засгийн газраас авсан боловч Ганц хутаг, Зуунмодын Цагдан хорих ангийн дарга Сугаржав, Очирбат нар тусгай илтгэгчийн мэдээлэл цуглуулах бүрэн эрхийг илт зөрчиж, хоригдож байгаа хүмүүсийг эрүүдэн шүүх, хэрцгий хүнлэг бусаар харьцсан тухай мэдээллийг шалгах явдалд санаатайгаар саад учруулсан юм. Тэд тусгай илтгэгчийг 2005 оны 6 дугаар сарын 8–9 өдөр очиход цагдан хорих байрны бүртгэлтэй танилцах, хүмүүстэй нь уулзуулахаас татгалзсан.

52. Үүний дараа тусгай илтгэгч Засгийн газраас сүүлийн гурван жилийн хугацаанд цаазаар авах ялаар шийтгэгдсэн, давж заалдаад шийдвэр хэвээр батлагдан ял гүйцэтгэхийг хүлээж байгаа хүмүүс, өршөөгдсөн хүмүүс, эдгээр ялтнуудын байрлаж байгаа нарийвчилсан байрлал, болон гүйцэтгэгдсэн хүмүүс, тэдгээрийг хаана оршуулсан талаарх мэдээллийг хүссэн юм. Тусгай илтгэгч цааш нь цаазаар авах ялаар шийтгэгдсэн хүмүүсийн хоригдож байгаа байрны нөхцөл байдлын талаар мэдээлэл өгөхийг хүссэн. Цаашилбал Ганц хутаг, Зуунмодын цагдан хорих байрны дарга нараас хамтран

ажиллахаас татгалзсан талаар тайлбар өгөхийг хүссэн юм. Бичиж байх хугацаанд Засгийн газрын зүгээс аливаа мэдээлэл ирүүлээгүй байна.

53. Засгийн газраас хамтран ажиллах явдал дутагдалтай байсан болохоор тусгай илтгэгч гэр бүлийн гишүүд болон төрийн бус байгууллагуудын өгсөн нотлогдсон мэдээлэл дээр тулгуурлан дүгнэлтийг хийсэн болно. Цаазаар авах ялаар шийтгэгдсэн ялтан хэт тусгаарлагдсан байдалд хоригдож, байнга гав, дөнгөтэй хоригдож, хангалттай хоол хүнсээр хангагдахгүй байгаа факт нь нэмэлт ял шийтгэл болж энэ нь “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц”-ийн 1 дүгээр зүйлийг заасан эрүү шүүлт гэж үзэж болохоор байна.

54. Цаашилбал тусгай илтгэгчийн уулзсан цаазаар авах ялаар шийтгэгдсэн хүмүүсийн нэг болох Сэдэдийн Батаагийн хэргээр (хавсралтыг үз) нөхцөл байдлын хахир хатуу байдлыг тодорхой харуулж байна. Тэрээр дараа нь эрүү шүүлтээс болж нас барсан гэж тусгай илтгэгч дүгнэсэн.

#### **I. Дүгнэлт, зөвлөмж**

55. Тусгай илтгэгч Засгийн газар сүүлийн жилүүдэд хүний эрхийн талаарх олон улсын стандартад Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийг нийцүүлэхээр нэмэлт өөрчлөлт оруулан тодорхой арга хэмжээ авсан болохыг тэмдэглэж байна. Гэхдээ эдгээр заалтаас үл хамааран гэмт хэргийн сэжигтнүүдийг эрүүдэн шүүх, тэдэнтэй хүнлэг бусаар харьцах явдал байнга гарч, үйлдэгчид шийтгэл хүлээлгэхгүй байх, түүний хохирогчдыг хамгаалах хууль эрх зүйн хамгаалалт, нөхөн олговор төлөх, нөхөн сэргээх зохистой үр нөлөө бүхий тогтолцоо практикт үгүйлэгдэж байна гэсэн дүгнэлтийг тусгай илтгэгч гаргаж байна.

Иймд Тусгай илтгэгч Монгол Улсын Засгийн газарт дараах зүйлийг зөвлөмж болгож байна. Үүнд:

а) Өндөр албан тушаалын хүмүүс ялангуяа хууль сахиулах үйл ажиллагаа явуулдаг албан тушаалын хүмүүст шийтгэл үзүүлдэггүй хэв заншлыг эцэс болгож, төрийн албан хаагчдын үйлдсэн эрүү шүүлт болон хэрцгий хүнлэг бус харьцах явдлыг хүлээн зөвшөөрөхгүй, мөрдөн шалгадаг болохыг салаа утгагүйгээр тунхаглан зарлах;

б) Эрүү шүүлтийн гэмт хэргийг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 1 дүгээр зүйлд заасантай нийцүүлэн тодорхойлж, ял шийтгэл нь эрүүдэн шүүхийн онц хүнд хэлбэртэй дүйцсэн байх;

в) Хуулийн дагуу баривлагдсан этгээдийг мөрдөн байцаагчийн хяналтад шүүхээс цагдан хорих зөвшөөрөл авахын тулд хуульд заасан 48 цагаас хэтрэхгүй хугацаагаар саатуулан хорихгүй байх. Энэ хугацааны дараа тэдгээр хүмүүсийг өөр эрх бүхий байгууллагын хяналтад цагдан хорих байранд шилжүүлэх ёстой. Тэнд мөрдөн байцаагчтай цаашид хяналтгүй холбоо барих явдлыг зөвшөөрөхгүй байх;

д) Цагдан хорих бүртгэл хөтлөлтийг нягт хийх явдлыг хангах үүнд, баривчлах цаг хугацаа, газар, цагдаагийн ажилтны нэр, дугаар, цагдан хорих байр, цагдан хорих төвд ирэх үеийн эрүүл мэндийн байдал, гэр бүл, өмгөөлөгчтэй холбоо барих, цагдан хоригдож байгаа этгээд дээр ирсэн цаг хугацааг тэмдэглэх, цагдан хорих төвд авчрах болон

шилжүүлэх үед эрүүл мэндийн шаардлагатай үзлэг хийх зэрэгт тэмдэглэл хөтлөх;

е) Өмгөөлөгчийг байлцуулалгүйгээр цагдан хорих байранд байхдаа хийсэн болон шүүхийн өмнө нотлогдоогүй хэрэгт хэрэг хүлээх явдлыг хэрэг хүлээсэн хүний эсрэг нотлох баримт болгон хүлээн авахгүй байх. Мөрдөн байцаалтын өрөөнд явуулсан байцаан шийтгэх ажиллагааны үеэр бүх хүмүүсийг байлцуулан хийсэн видео болон аудио бичлэгийг давуу байдлаар авч үзэх хэрэгтэй;

ф) Шүүгч, прокурорууд цагдан хорих байрнаас авчирсан хүмүүсээс тэдэнтэй хэрхэн хандаж байсан талаар тогтмол асууж байх, хариуцагчаас албан ёсны гомдол байхгүй үед ч бие даасан эмнэлгийн үзлэг хийж байхыг тушаах;

г) Эрүүдэн шүүх болон хэрцгий хүнлэг бусаар харьцсан тухай бүх мэдээллийг шуурхай, няхуур шалгах хараат бус эрх бүхий этгээд мэдээлэл өгсөн хохирогчийн эсрэг хэргийг мөрдөн байцаах болон шалгах явдалтай аливаа холбоо хамааралгүй байдлаар мөрдөн шалгаж байх. Тусгай илтгэгчийн үзэж байгаагаар Хүний эрхийн Үндэсний Комисст энэ чиг үүргийг даалгаж болох юм;

h) Төрийн албан хаагчаас хүч хэрэглэн эрүүдэн шүүн ял хүлээлгэх явдал байгаа бөгөөд эрүүдэн шүүн хуйвалдах, нотлох баримтыг үл ойшоох явдалд оролцсон прокурор, шүүгч нарыг шүүх хуралдаан явуулах болон яллах үүргийг даруй түдгэлзүүлэх;

и) Эрүү шүүлт, хэрцгий, хүнлэг бус харьцах явдалд өртөж хохирсон хохирогчид бодитой нөхөн олговор болон шаардлагатай эмчилгээ, нөхөн сэргээлтийг авах нөхцөл бүрдүүлэх;

j) Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 22 дугаар зүйлтэй нийцүүлэн Эрүүдэн шүүхийн эсрэг хороо конвенцийн заалтыг зөрчснөөс хохирсон хохирогч этгээдээс гаргасан захидал харилцааг хүлээн авч хянан үзэх эрхийг хүлээн зөвшөөрсөн тунхаглалыг гаргах;

к) Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд шүүх хурлаар хэрэг нь орох гэж байгаа этгээдийг ялангуяа хүнд биш хэрэг, насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн хэрэг, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цагдан хорих байранд хорьдог нийтлэг журмыг хэрэглэхгүй байж, цагдан хорихгүй батлан даалтад гаргах зэрэг таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх явдлыг нэмэгдүүлэх байдлыг хангах талаар нэмэлт өөрчлөлт оруулах. Цаашилбал урьдчилан хорих байранд хорих хамгийн дээд талын хугацааг ялангуяа 18 насанд хүрээгүй этгээдэд хэрэглэж байгаа хугацааг багасгах, урьдчилан хорих хугацааг хамгийн эцсийн арга хэмжээ болгож, хамгийн богино хугацаагаар шүүгч авч байх;

l) Удаан хугацаагаар хорих ялаар шийтгэгдсэн ялтанд хэрэглэж байгаа одоогийн онцгой дэглэмийг эцэс болгож, эрх чөлөөгөө хасуулсан бүх этгээдийг Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм, Иргэний болон улсын төрийн эрхийн тухай олон улсын пактын 10 дугаар зүйлд заасан засан хүмүүжүүлэн, дахин нийгэмшүүлэх зорилготой нийцүүлэн хорьж байх явдлыг хангах;

Цаазаар авах ялаар шийтгэгдсэн ялтныг Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн дагуу хорьж, ялангуяа цагдан хорих байранд байх үед нь гавлаж дөнгөлөхгүй байх;

m) Цаазаар авах ялыг халах үүднээс цаазаар авах ялыг түр хойшлуулан оногдуулж байх болон Засгийн газар Иргэний болон улсын төрийн эрхийн тухай пактын хоёр дахь



нэмэлт протоколыг соёрхон батлах хэрэгтэй;

п) Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколыг соёрхон баталж, хараат бус хяналт шинжилгээний механизмыг бүрдүүлж, эрх чөлөөгөө хасуулсан хүмүүс байдаг улсын хэмжээнд байгаа бүх газруудад очиж үзэж байх. Тусгай илтгэгчийн үзэж байгаагаар энэ механизм нь Хүний эрхийн Үндэсний Комиссын хүрээнд байж болох юм;

о) Хууль сахиулах байгууллагад шинээр ажилд орж байгаа хүмүүс хүний эрхийн боловсролтой холбогдолтой эрчимжүүлсэн, нарийвчилсан сургалтын хөтөлбөрт хамрагдсан байх бөгөөд сургалтад мөрдөн байцаах арга техник, цагдаагийн тоног төхөөрөмжийг зохих журмаар хэрэглэх зэргийг оруулж одоогийн офицерүүдийг үргэлжлүүлэн сургалтад хамруулах;

р) Системчилсэн сургалтын хөтөлбөр, олон нийтийн мэдээлэл сурталчилгааг нэмэгдүүлэх компани ажлыг олон нийт, хууль сахиулах байгууллагын албан хаагчид, хуульч мэргэжилтнүүд болон шүүхийн ажилтнуудад зориулан Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцийн зарчмуудаар зохион байгуулах;

56. Тусгай илтгэгч Засгийн газрыг олон улсын холбогдох байгууллага тухайлбал НҮБ-ын Хүний эрхийн Дээд комиссариатын газраас дээр дурдсан зөвлөмжүүдийн талаар цаашид авах арга хэмжээнд туслалцаа дэмжлэг хүсэхийг тус тус зөвлөж байна.

### **Хавсралт**

Тодорхой хэргүүд

Шалгалтын явцад дараах хүмүүстэй уулзаж ярилцсан бөгөөд тэдгээрийн гомдлыг 2005 оны долдугаар сарын 20-н болон наймдугаар сарын 2-ны өдрийн Засгийн газарт хандсан захидлаар хүргүүлсэн билээ. ЗГ 2005 оны есдүгээр сарын 22-ны захидлаараа тэдгээр захианд хариу ирүүлсэн болно.

1. Дамиран Энхбатын 44 настай (өмнөх гомдол хариу ирээгүй E/CN/4/2004/56/add 1021-р хэсэг). 2003 оны тавдугаар сарын 15-ны орчимд Францад цагаачлахаар очоод байсан Энхбатын Дамиранг Парисын нэгэн рестораны өмнө ТЕГ-ын хэсэг ажилтан барьж зодоод элчингийн машинд суулган Бельги дэх элчин сайдын яамаар дамжуулан улмаар Герман улсын ЭСЯ-ны байранд хүргэсэн байна. ЭСЯ-нд нэг хонуулахдаа ТЕГ-ын ажилтнууд түүнийг эрүүдэн шүүсэн бөгөөд маргааш нь дугуйт тэргэнд суулган МИАТ-ийн онгоцоор тавдугаар сарын 18-ны өдөр УБ руу авч одсон байна. Монгол Улсын хилээр нэвтрэн орсон тэмдэглэгээ хийгдээгүй бөгөөд хотын гаднах нууц байранд хорьжээ. Ардчиллын удирдагч тухайн үедээ дэд бүтцийн сайд асан С.Зоригийн аллагад ял тулган эрүүдсэн хэдий ч хэрэг хүлээгээгүй байна. Тавдугаар сарын 24-нд түүнийг ТЕГ-ын мэдээлэгч гэж бүртгээд мөн сарын 25-нд хилээр нэвтэрсэн мэтээр бүртгэжээ. Олон цагаар сандал дээр суух, буугаар элгэн тус газар балбах, хуурамчаар цаазаар авах зэрэг арга байдлаар тарчлааж байжээ. 2003 оны 6 дугаар сард 58 настай өмгөөлөгч Лодойсамбуугийн Санжаасүрэн нь Д.Энхбаттай уулзах үеэрээ хэрхэн хулгайлсан, тарчлааж байсан талаар ярилцлага хийн 36 минутын видео бичлэгээр баримтжуулж чаджээ. Үүнийгээ есдүгээр сарын 27-нд Монголын 25 дугаар телевизийн сувгаар цацсан байна. Энэ нь хуучин тагнуулын ажилтан Лодойсамбуугийн Санжаасүрэнгийн эсрэг

(эрүүгийн хуулийн 87/1)–ийн дагуу төрийн нууц задруулсан гэх хэргийг үүсгэх үндэслэл болжээ. 2004 оны 11 дүгээр сард уг хэргээр 18 сар хорих ял хүлээж Амгалан дахь 421 дүгээр жирийн дэглэмтэй хориход ялаа эдэлсэн байна. Тусгай илтгэгч 2005 оны 6 дугаар сарын 7–нд зүрхний хүнд өвчтэйгээр эмчлүүлж байхад нь түүнтэй очиж уулзсан болно. Түүний мэдүүлж байгаагаар эмнэлгийн тусламж аваагүйгээс гадна тодорхой эм тариаг авч байгаагүй гэнэ. 2005 оны 6 дугаар сарын 7–нд Зүүн хараагийн 413 дугаар чанга дэглэмтэй хориход төрийн нууц задруулсан хэрэгт 3 жилийн ял эдэлж буй Д.Энхбаттай уулзсан. Хүний амийг санаатайгаар хороосон хэргийг угаас худал байсан тул хэрэгсэхгүй болгожээ. Уулзалтын үеэр хөндлөнгийн эмчийн үзлэгт оруулахад амьсгал нь хүнд, шээс нь цустай, чичрэх зэрэг шинж тэмдэг нь биеийн байдал тааруухан болохыг илтгэж байна. Иймд яаралтай эмнэлгийн тусламж шаардлагатай байна. Зайсан дахь хорих эмнэлэгт шилжсэн хэдий ч дорвитой эмчилгээ авалгүй эрс муудаж буй эрүүл мэндийн байдлыг эс харгалзан буцаасан байв. Д.Энхбатыг тарчлаан зовоож эрүүдэн шүүсэн гэх гомдлыг хариу ирүүлэхийг илтгэгч шаардаж байна. Энэхүү 2 хоригдол хоёулаа Ерөнхийлөгчид өршөөл хүсэн хандсан бөгөөд Тусгай илтгэгч тэдгээрийн эрүүл мэндийн байдлыг харгалзан үзэж хүнлэг хандах үүднээс өршөөл үзүүлэхийг Ерөнхийлөгчөөс хүсжээ. Үүний гадна төрийн нууц задруулсан гэх ял нь олон улсын хүний эрхийн талаарх хуулийг зөрчиж байна гэж үзэв. Өмгөөлөгчийн хувьд Л.Санжаасүрэн нь ТЕГ–аас тарчлаасан талаар ултай баримт цуглуулах улмаар уг мэдээллийг олон нийтэд хүргэх эрхтэй байсан гэж үзэж байна.

2. 2005 оны 9 дүгээр сарын 2–нд ирүүлсэн хариунд Дамирангийн Энхбат нь хоригдож байх хугацаандаа зохих эмчилгээг авч байсан гэж Засгийн газар мэдэгдэж байна. Өнгөрсөн хугацаанд хорихын эмнэлэгт 8–н удаа мөн бусад 1, 2, 3 дугаар эмнэлэгүүдийн мэргэжлийн тасагт эмчлүүлж хууль, дүрмийн дагуу хандаж байсан гэжээ. Гэвч тусгай илтгэгчийн үзэж байгаагаар Энхбатыг олон улсын эрх зүйг ноцтойгоор зөрчиж шийтгэсэн тул нэн даруй суллах шаардлагатай гэж үзэж байна. Нөгөө талаас эрүү шүүлтийг хийсэн этгээдүүдийн эсрэг шүүх ажиллагааг эхлүүлэх хэрэгтэй.

3. Чингэлтэй дүүргийн шүүх нь Лодойсамбуугийн Санжаасүрэнг 18 сараар хорих ялаар шийтгэсэн тул 421 дүгээр жирийн дэглэмтэй хориход ялаа эдэлж байна хэмээн ЗГ мэдэгдэв. Хагас ялыг эдэлсний дараа 2005 оны 8 дугаар сарын 9–нд Баянзүрх дүүргийн шүүхээс урьдчилан магадлангаар түүнийг сулласан байна. 9 сар ял эдлэхдээ хорихын төв эмнэлэгт 72 өдрийг өнгөрөөсөн байна. Зүрхний эмчилгээг 3 дугаар эмнэлэгт хийлгэсэн юм байна. Урьдчилан магадлангаар сулласан явдлыг Тусгай илтгэгч сайшаагаад өмгөөлөгчийнх нь хувьд бүрэн цагаатгахыг хүсч байна.

4. Мөнхбаатарын Баатар нь 35 настай. 2005 оны 5 дугаар сарын 17–нд ойролцоогоор 11 цагийн орчимд хүний амийг санаатайгаар хөнөөсөн хэрэгт сэжиглэгдэн Ганц худгийн 461 дүгээр урьдчилан хориход Баянзүрх дүүргийн шүүх, прокурорын зөвшөөрөлтэйгээр баривчилсан байна. Ганц худагт ирэх үеийн эрүүл мэндийн үзлэгээр ямар нэгэн гаж зүйл тэмдэглэгдээгүй. 5 дугаар сарын 20 ны 11 цаг 50 минутад мөрдөгч Бүрхүү Баатарын эгч рүү утасдаж дүүгээ ирж авахыг хүссэн байна. Авахаар ирэхэд Баатар нь ихээр зодуулж цус нөжтэйгээ холилдсон байжээ. Тэр даруй шүүх эмнэлэгт хүргэгдэн зураг авч эрүү шүүлтийг баримтжуулсан байна. Дэргэд нь орших эмнэлэгт тархины зураг

авхуулахад тархи гэмтэлтэй нь тогтоогдож мэдрэлийн тасгийн тархи нугасны хэсэгт оройн 5 цагт хэвтсэн байна. Баатар 5 дугаар сарын 29-нд эмнэлэгт нас барсан.

Тусгай илтгэгч баримт материал, тархины гэрэл зурагтай танилцжээ. 6 дугаар сарын 7-нд Ганц худагт очих үеэр түүний дарга Сугаржав хамтран ажиллахаас татгалзсан юм.

Гэсэн хэдий ч тусгай илтгэгч хорихын бүртгэлтэй танилцаж чадсан бөгөөд Баатарын гэр бүлийнхэнтэй 6 дугаар сарын 9-нд уулзаж амжсан байна. Хангалттай нотлох баримтын хүрээнд шалгалт хийсний үр дүнд тусгай илтгэгч Баатарыг эрүүдэн шүүсээр (түүний мөрдөнд очихоос хэд хоногийн өмнө) амь насыг нь хөнөөсөн байна гэсэн дүгнэлт хийжээ. Иймд уг хэргийг шүүн буруутныг шийтгэх талаар авч хэрэгжүүлсэн мэдээллээ ирүүлэхийг шаардаж байна.

5. 2005 оны 9 дүгээр сарын 22-нд илгээсэн захидалдаа Зүүн Хараагийн 461 дүгээр хорих ангийн ажилтанг баривчилж, эрүүгийн хэрэг үүсгэсэн гэж мэдэгдсэн.

6. 41 настай Батжаргалан Баярбат нь 2001 онд үйлдсэн хэд хэдэн хүн амины хэрэгт 30 жилийн ялаа Тахир соёотын 405 дугаар гянданд одоо эдэлж байна. 405 дугаар ангид шилжиж ирэхээс өмнө Ганц худгийн урьдчилан хорих газарт 3 жил хоригдсон бөгөөд эрүүдэн шүүсний улмаас гэм буруугаа хилсээр хүлээсэн гэж гомдоллосон. 3 жилийн турш гав дөнгөтэй байж тамхины цогоор түлүүлж талхаар зодуулж, бусад хоригдогч нартаа дээрлэхүүлж байжээ. Идэж ууж чадахгүй байсан тул 56 кг-аар турсан гэнэ. 2005 оны 6 дугаар сарын 8-нд очиж ярилцах үедээ хөндлөнгийн эмчийг авч очиж шалгуулахад бугуй шагайн тус газар мөн бүх биеийн эргэн тойронд шарх сорви болсон нь түүний мэдүүлэгтэй тохирч байна. Ихээхэн жин алдсан болох нь илт байв. Тусгай илтгэгч эрүүдэн шүүсэн талаар мөрдөн шалгах ажиллагаа эхлүүлэхийг шаардсан. Түүнээс гадна ял нь эрүүдэн шүүх замаар хилсээр гэм буруугаа хүлээсэн гэх нотолгоон дээр үндэслэсэн тул ЭШЭК-ийн 15 дугаар зүйлд харшилж байгаа тул дахин шүүхээр хэргийг авч үзэх эсвэл суллах шаардлагатай.

7. Засгийн газрын мэдэгдэлд түүнийг төв хорих эмнэлэгт эмчилгээнд хамруулсан гээд ялаа эдэлснээс хойш жин алдаагүй одоогоор 59 кг бөгөөд эрүүл мэндийн байдал хэвийн гэж байв. Түүний Дээд Шүүх, УЕПГ-т гаргасан өргөдлийг зохих газар шилжүүлсэн гэжээ. Гэвч Тусгай илтгэгчийн үзэж байгаагаар гэм буруутайг нотлохдоо тарчлаан зовоосон тул уг хэргийг дахин шүүх эсвэл Баярбатыг суллаж, нөхөн олговор өгөх ёстой гэж үзэж байна.

8. Жирийн дэглэмтэй 405 дугаар хорих ангид хоригдож байгаа Ганбаатар нь 2003 онд анх ирэхэд жагсаалд оройтсон хэмээн толгой руугаа бороохойдуулах тохиолдол гарч байсан бөгөөд үүнийг гол төлөв Цэндрагчаа, Бат-Эрдэнэ нар үйлдэж байжээ. Нэг удаа торонд гавлуулан зодуулсны дараа шөнөжин гавтайгаа хонож байжээ. 2005 оны 6 дугаар сарын 7-нд тусгай илтгэгчтэй ярилцах үеэр хамгийн сүүлд 5 дугаар сарын 27-нд зодуулахдаа сандалтай гавлагдан бороохойдуулсан гэж байв. Хөндлөнгийн эмчийн шалгалтаар нүүр толгойн тус газар хөхрөлт байсан тул түүний мэдүүлэг үнэн зөв болохыг нотолж байна. Ганбаатарын хэлж байгаагаар гомдол саналыг эс тоодог гэнэ. Ерөнхийдөө хоригдлуудыг хянагч нар зодох нь хэвийн үзэгдэл болжээ. Тэд шалгагчийг тоогоогүй шоронгийн дүрэм зөрчсөн, ажил хийхдээ цонхоор гөлөрсөн зэрэг үл ялих шалтгаанаар зоддог гэсэн байна. Шалгагч нарын хоол хийгээд амт нь таалагдахгүй шалтгаанаар

зодуулсан тохиолдол гарчээ. Хоригдлууд эмчид хэлдэггүй бөгөөд үүний шалтгаан нь эмч, шалгагч нарт хэлсэнээр улам их зодуулах болдог юм байна. Зүй бус харьцааны талаар тусгай илтгэгч мэдээлэл хүссэн боловч хариу ирээгүй байна.

9. Сэдэдийн Батаа 37 настай. 2005 оны 6 дугаар сарын 9-нд уулзахыг хүссэн боловч Зуунмод дахь урьдчилан хорих газрын дарга Очирбат олгосон эрх мэдлийг хөсөрдүүлэн уулзуулаагүй билээ.

Цаазаар авах ялаа хүлээх зуур тамлагдан зовж, 24 цаг гав гинжтэй байгаа талаар баттай эх сурвалж мэдээлж байна. 2005 оны 7 дугаар сарын 22-нд Батаа Зуунмодоос 405 дугаар ангид хүргэгдсэний дараа нас барсан байна.

Ийнхүү тарчлаан Сэдэдийн Батаагийн амийг хөнөөсний дараа 2005 оны 8 дугаар сарын 2-ны захидлаар ЗГ-ыг НҮБ-ын Суурин төлөөлөгчийн газартай хамтран ажиллаж эдгээр хэргүүдийг шалгаж үзэхийг уриалаад (бүх газарт шаардлагатай хүн материалыг шалгуулах) 15 хоногийн дотор хариу мэдэгдэхийг шаардсан. Эхлээд Сэдэдийн Батаатай Зуунмод дахь хориход уулзуулаагүй дараах нь түүнийг тарчлааж байгаад амийг нь хөнөөсөн нотлох баримт байгаа нь тусгай илтгэгч энэ талаар ихээхэн санаа зовж байгаагаа илэрхийлж байна.

**10.3 НҮБ–ЫН СУРЧ БОЛОВСРОХ ЭРХ ХАРИУЦСАН ТУСГАЙ  
ИЛТГЭГЧ ВЕРНОР МУНОЗ ВИЛЛАЛОБОСЫН ТАЙЛАН  
2009 оны 10 дугаар сарын 1–8**

**МОНГОЛ УЛС ДАХЬ ТОМИЛОЛТ**

**Товч илтгэл**

Сурч боловсрох эрхийн хэрэгжилттэй танилцахаар НҮБ–ын тусгай илтгэгч 2009 оны 10 дугаар сарын 1–нээс 8–ны өдрүүдэд Монгол Улсад айлчилж, нийслэл хот Улаанбаатар, баруун бүсийн Ховд аймгийн сумдаар зочилж нөхцөл байдалтай танилцлаа. Тэрбээр засгийн газрын холбогдох хүмүүс, сургуулийн захирал, багш нар, боловсролын мэргэжилтнүүд, академичид, оюутнууд, эцэг эхчүүд, үйлдвэрчний эвлэлийн болон иргэний нийгмийн төлөөлөгчид мөн Монгол Улс дахь НҮБ–ын агентлагуудын суурин төлөөлөгчидтэй уулзаж, цэцэрлэгээс авахуулаад олон их сургуулиудаар зочилсон. Айлчлалын гол зорилго нь Монгол Улс хүний сурч боловсрох эрхийг хэрхэн хэрэгжүүлдэг, амжилттай хэрэгжүүлэхэд мөн бэрхшээл тулгарахад ямар арга хэмжээ авдаг, хэрхэн шийддэг талаар ойлголт авахад оршино.

Энэхүү илтгэлд, тусгай илтгэгч нь сургалт, үйл ажиллагааны хүрээ, дэд бүтцийн зохион байгуулалт болон боловсролын санхүүжилт, тусгай хөтөлбөр, насанд хүрэгчдийн боловсрол зэрэг Монгол Улсын боловсролын системийн гол шинжүүдэд задлан шинжилгээ хийсэн. Мөн тэрбээр айлчлалынхаа үеэр олж харсан зарим сайн туршлагуудыг онцлон тэмдэглэсэн байна. Тухайлбал сургуульд элсэлтийн хувь хэмжээ өндөр, Монгол Улсын нийгэм хэрхэн боловсролыг чухалчилдаг болох үүнд гэр цэцэрлэгүүд, үдийн цай хөтөлбөр, цөөнхөд зориулсан боловсролын хөтөлбөр болон тухайн орны цаг уурын нөхцөл, өргөн уудам талд зохицсон бүтээлч байдлыг харуулсан холын зайны сургалт зэрэг орсон.

Тусгай илтгэгч нь Монгол Улсын боловсролын системд тулгарч буй зарим асуудлыг хэлэлцсэн байна. Үүнд сургуулиас завсардах явдал, бодит статистик тоо баримт болон ундны ус, ариун цэврийн нөхцөл байдал хангалтгүй байх зэрэг сургуулийн дэд бүтэц, хөдөө орон нутаг дахь оюутнуудын дотуур байрны нөхцөл байдал, мөн хөдөө орон нутгаас хот руу шилжин суурьшиж буй үзэгдэл хотын сургуулиудад ачаалал үүсгэж буй явдал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол зэрэг асуудал орж байна.

Тусгай илтгэгч дүгнэлтдээ, хүний эрхийн соёл руу урагшлан тэмүүлж, боловсролыг үйлчилгээ бараа таваар мэт үзэх биш, харин хүний үндсэн эрх буюу хөгжилд хөтлөх хөдөлгөгч хүч хэмээн үзэх хэрэгтэй гэж онцлон тэмдэглэсэн. Тэрээр Монгол Улсын нутаг дэвсгэр, цаг агаар болон эдийн засгийн уналтын байдлыг үл харгалзан, дээрх бэрхшээлүүдийг даван туулах тусгай зөвлөмжүүдийг өгсөн.

**Хавсралт**

**СУРЧ БОЛОВСРОХ ЭРХИЙН ТУХАЙ ТУСГАЙ ИЛТГЭГЧИЙН ИЛТГЭЛ  
ВЕРНОР МУНОЗ ВИЛЛАЛОБОС МОНГОЛ УЛС ДАХЬ ТОМИЛОЛТ  
(2009 оны 10 дугаар сарын 1–8)**

**I. Удиртгал**

1. Сурч боловсрох эрхийн хэрэгжилттэй танилцахаар НҮБ–ын тусгай илтгэгч 2009 оны 10 дугаар сарын 1–нээс 8–ны өдрүүдэд Монгол Улсад айлчлав. Айлчлалын гол зорилго нь Монгол Улс хүний сурч боловсрох эрхийг хэрхэн хэрэгжүүлдэг, амжилттай хэрэгжүүлэхэд, бэрхшээл тулгарахад ямар арга хэмжээ авсан талаар хамтын ажиллагаа болон харилцан хэлэлцээрийн зүгээс ойлгоход оршино.

2. Тусгай илтгэгч нь нийслэл хот Улаанбаатар, алслагдсан Налайх дүүрэг болон баруун бүсийн Ховд аймгийн Жаргалант, Ховд, Мянгат сумуудад зочилсон. Тэрээр Засгийн газрын холбогдох хүмүүс, Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Сайд, боловсролын дэд сайд, мөн боловсролын янз бүрийн салбарын удирдлагууд, боловсролын судалгааны хүрээлэн болон төвүүдийн захирлууд, мөн Нийгмийн Халамж Хөдөлмөрийн Яамны ахлах мэргэжилтнүүд, Гадаад Хэрэг, Худалдааны Яам болон түүний дэд сайд зэрэг албаны хүмүүстэй уулзлаа. Мөн тэрээр Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, Улаанбаатар дахь Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн ректор болон ахлах мэргэжилтнүүд, Ховд сум дахь Ховдын Их Сургууль, сургуулийн захирал, багш нар, боловсролын мэргэжилтнүүд, академичид, оюутнууд, эцэг эхчүүд, үйлдвэрчний эвлэлийн төлөөлөгчидтэй уулзлаа.

3. Тусгай илтгэгч нь иргэний нийгмийн төлөөллүүд болон Монгол Улс дахь НҮБ–ын салбар агентлагуудын удирдлагуудтай уулзалт зохион байгууллаа. Тусгай илтгэгч нь энэхүү айлчлалыг амжилттай зохион байгуулахад тусласан НҮБ–ын Хүүхдийн сан болон өөрийг нь хүлээн авч уулзсан байгууллага, хамт олонд баярласан талархсанаа илэрхийлэхийг хүсч байна. Мөн тэрээр уулзалтад оролцсон хүмүүс илэн далангүй байж, зарим нэг нь өөртөө шүүмжлэлтэй хандаж байсан явдалд гүн талархсанаа илэрхийлж байна. Зарим нэг нөхцөл байдал, бэрхшээлтэй тулгардаг ч Монгол Улсын Засгийн газар хүн бүрт боловсрол олгох гэсэн ил тод байр суурьтай байдгийг янз бүрийн уулзалтаас олж харсан бөгөөд энэ нь талархууштай зүйл гэж үзэж байна.

**II. Сурч боловсрох эрх: зарчим, норм, хэм хэмжээ**

**A. Олон улсын хууль эрх зүйн хүрээ**

4. Монгол Улс нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц, Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг нь гутаан доромжилж, харьцаж

шийтгэхийн эсрэг конвенц болон Хүүхдийн эрхийн тухай конвенцид тус тус нэгдэж орсон. Түүнчлэн, Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхах явдлыг устгах хороо болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хувь хүний гомдол хүлээн авах нэмэлт механизмд нэгдэн орж, мөн олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм соёрхон баталсан.

5. 1948 оны Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын хамт эдгээр олон улсын хүний эрхийн гол баримт бичгүүдэд сурч боловсрох эрхийг баталгаажуулсан байдаг. Энэхүү эрхтэй хамааралтай чухал заалтуудад гишүүн улс бүр үндэсний түвшинд хууль тогтоомж болон бодлогын хүрээг хангах ёстой гэж тусгасан байдаг. Түүгээр үл барам олон улсын хүний эрхийн гэрээнд нэгдэн орсон гишүүн улсууд нь гэрээний болзолд нөлөө үзүүлэх үүрэгтэй. Үүнд хамааралтай заалтууд нь Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай ОУ-ын пакт, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Сурч боловсрох эрхийн талаархи Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос гаргасан Ерөнхий зөвлөмж 11, 13 болно.

#### **Б. Орон нутаг дахь хууль зүйн орчин болон үндэсний бодлогууд**

6. Монгол Улс нь улс төр, засаг захиргааны хувьд 21 муж буюу аймагт хуваагдах бөгөөд захиргааны нийслэл хот нь Улаанбаатар хот юм. Аймгийн төв нь орон нутгийн нийслэл болно. Аймаг тус бүр нь захиргааны жижиг нэгж болох дүүрэг буюу сумдад хуваагдаж, сум нь сумын төвтэй байна. Сум нь багтай байх бөгөөд энэ нь үндсэндээ тосгон юм. Айл өрх бүр сонгогдсон багийн зөвлөлд төлөөлөгчөөр байх эрхтэй. Эдгээр зөвлөл нь сумын зөвлөлийг сонгож, сум нь аймгийн зөвлөлийг сонгодог. Аймгийн зөвлөл засаг даргаар ажиллах хүнийг санал болгох бөгөөд засаг даргыг ерөнхий сайд томилно.

7. Одоо мөрдөж буй Үндсэн Хуулийг 1992 оны 1 дүгээр сард баталж, 1999 болон 2001 онд нэмэлт өөрчлөлт оруулсан юм. Үндсэн хуулийг баталснаар олон намын системтэй ерөнхийлөгчийн хагас засаглалтай ардчилсан улс болсон билээ. Энэ үед Үндсэн Хуулийн Цэц байгуулагджээ. Хуулийн хоёрдугаар бүлэгт хүний эрх, эрх чөлөөний тухай заасан байдаг. Эдгээр эрх, эрх чөлөөний тухай ихэнх нь эвлэлдэн нэгдэх эрх, шүүхэд хандах эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, шашин шүтэх, эс шүтэх эрх зэрэг иргэний болон улс төрийн шинж чанартай эрхүүд ордог. Үүнээс гадна, эрүүл аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалаалуулах, эмнэлгийн тусламж авах, мөн соёл урлаг, шинжлэх ухааны салбарт уран бүтээл чөлөөтэй туурвих эрх зэрэг эдийн засаг, нийгэм соёлын зарим эрхийг хамгаалахыг тусгасан байдаг.

8. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын хуулийг 2000 оны 12 дугаар сард УИХ баталснаар Монгол Улс нь хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих үүрэг бүхий хүний эрхийн үндэсний байгууллагатай болсон. Хүний эрхийн Үндэсний Комисс нь 2001 оны 1 дүгээр сараас үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн билээ. Тус Комисс нь жил бүр Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний нөхцөл байдлын тухай илтгэл боловсруулдаг.

9. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 7 дугаар хэсэгт, иргэн бүр сурч боловсрох эрхтэй хэмээн заасан байдаг. “Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгоно”, мөн “иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль

байгуулан ажиллуулж болно” гэсэн нөхцөл тавин тусгайлан заасан байдаг.

10. Монгол Улсын боловсролын салбар дахь хууль зүйн нарийвчилсан зохицуулалтыг Боловсролын тухай хуульд тусгасан бөгөөд уг хуулийг 1995 онд шинэчлэн найруулж, 2002 онд нэмэлт өөрчлөлт оруулжээ. Уг хуульд боловсролын тэгш байдал, үнэ төлбөргүй албан боловсролын заалт зэрэг боловсролын үндсэн зарчмуудыг тусгасан байдаг. Боловсролын тухай хуулийн дагуу боловсрол нь ард иргэдийг бие даан сурч, ажиллаж, амьдрахад зохих оюун ухаан, сэтгэл зүй, бие бялдрын ур чадварыг эзэмшүүлэх зорилготой юм.

11. Монгол Улсын Парламент нь Төрийн боловсролын бодлого, Дээд боловсролын тухай хууль, Анхан болон дунд шатны боловсролын тухай хуулийг тус тус баталсан. Эдгээр хууль зүйн баримт бичиг нь Монгол Улс социалист систем болон төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас ардчилсан чөлөөт зах зээл рүү шилжсэнээс хойш буюу 1990 оноос хүчин төгөлдөр болж ирсэн ажээ. Эдгээр хуульд боловсролын засаг захиргааны тогтолцоонд ардчилсан нээлттэй бодлого явуулахыг тод томруун тусгасан билээ. Түүнчлэн улсын сургуулийн санхүүжилт болон засаг захиргааны төвлөрлийг багасгана гэж заасан байна. Аймаг тус бүрийн орон нутгийн захиргаанд сургуулиудын менежмент шилжиж, коллеж, их сургуулиуд нь өмнөх үетэйгээ харьцуулахад илүү бие даасан шинжтэй болжээ.

### **III. Монгол Улсын боловсролын системийн онцлох шинж чанарууд**

12. Өнөөгийн Монгол Улсын боловсролын системийг авч үзэхдээ тухайн улсын түүх болон гарч болох үр дагаврыг орхигдуулж болохгүй. Хуучин цагт боловсрол нь Буддын шашны сүм хийдийн удирдлагад байсан бөгөөд зөвхөн лам нараар хязгаарлагдаж байсан юм. 1911 онд Хятадын ноёрхол нуран унаснаар иргэний боловсрол нэвтэрч эхэлжээ. 1920–иод оны турш боловсрол аажмаар дэлгэрч, энэ үйл явц 1940 он хүртэл буюу олон нийтийн боловсролын систем бүрэн дүүрэн бүрэлдэн тогтох үе хүртэл үргэлжилсэн билээ. 1990 он хүртэл боловсролын систем нь Зөвлөлт Холбоот Улсын загварт тулгуурлаж байжээ.

#### **А. Боловсролын системийн засаг захиргаа ба менежмент**

13. Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам (БСШУЯ) нь тус улсын боловсролын системийг хариуцах засгийн газрын гол байгууллага юм. Боловсролын системтэй холбогдуулан, тус яам нь сургуулийн өмнөх сургалт хүмүүжлийн байгууллагаас насанд хүрэгчдийн боловсролын байгууллага хүртэлх улсаас санхүүжүүлэгддэг боловсролын бүхий л салбарыг хариуцан ажилладаг. Үндэсний сурах бичгийг хэвлэн гаргах, сургалтын төлөвлөгөөг батлах зэрэг хүн бүрт зориулсан цогц, тохиромжтой боловсролын системийг боловсруулах эрх үүрэгтэй. Түүнчлэн тус яам нь боловсролын системийн зохион байгуулалт болон холбогдох хууль зүйн эрх мэдлийн хэрэгжилтийн ерөнхий байдлыг хариуцан ажилладаг. БСШУЯ нь багш, сурган хүмүүжүүлэгчид гэх улсын боловсролын салбарт хамрагдах бүх боловсон хүчний сургалтыг уялдуулан зохион байгуулдаг.

14. Хэдийгээр боловсрол нь төвлөрсөн зохицуулалттай ч, орон нутгийн захиргаа,



удирдлагын зүгээс илүү практик, орон нутгийн түвшинд үүрэг хүлээдэг. Монгол Улсын 21 аймаг тус бүр албан болон албан бус боловсролтой хамааралтай нутгийн захиргааны бодлого үйлчилгээг хэрэгжүүлэх, удирдах үүрэг бүхий нутгийн захиргааны хамтаар нийгмийн бодлогын газарт хяналт тавьдаг. Эдгээр газар нь цэцэрлэг, бага болон дунд сургуулийг байгуулж, удирдан явуулдаг (мөн санхүүжүүлдэг). Мөн сургуулийн захирлыг томилох, чөлөөлөх зэрэг боловсролын салбарт хамааралтай орон нутгийн хууль тогтоомж гаргах үүрэгтэй.

15. Төвөөс бага болон дунд шатны боловсролын түвшний эрх мэдлийг орон нутгийн удирдлагуудад аль эрт олгосон ч, дээд боловсролын түвшинд энэ нь бүр ч илүү тодорхой байдаг. Их сургуулиуд нь нилээн бие даасан шинжтэй. Төв аль эсвэл орон нутгийн удирдлагын тавьсан зохицуулалтад нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулахаас илүүтэйгээр тухайн их сургууль нь өөрийн төсвөөр БСШУЯ дахь шийдвэр гаргах үйл ажиллагаанд идэвхтэйгээр оролцох жишээтэй. Их сургуулиуд нь сургалтын төлбөрийн орлого, санхүүжилт хайх болон гаднаас санхүүжилт авах зэргээр өөрийн нэмэлт санхүүжилтийг хангах эрхтэйгээрээ боловсролын бусад байгууллагуудаас ялгаатай юм.

#### **Б. Боловсролын системийн үндсэн тогтолцоо**

16. Монгол Улсын боловсролын түвшинд цэцэрлэг, ясли гэх сургуулийн өмнөх албан бус боловсрол орно. 2002 оны Боловсролын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн дагуу ерөнхий боловсролын тогтолцоонд 5-н жилийн анхан шатны боловсрол (7-11 нас), дараа нь 4-н жилийн дунд боловсрол (12-16 нас) ордог байна. Үүний дараа 2 жил ахлах сургуульд суралцаж төгссөнөөр их сургуульд орж болно. 2008/2009 оны хичээлийн жилээс эхэлж сургуульд орох нас нь 7 наснаас 6 нас болсон ч бага сургуульд суралцах нэг илүү жил нэмэгдсэн. Түүнчлэн Монгол Улсын боловсролын систем 12 жилийн сургалтын хөтөлбөртэй боллоо. Бага болон дунд шатны ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгодог.

17. Бага, дунд сургууль нь гол төлөв сургуулийн нэг байранд байдаг бөгөөд 10 хүртэлх ахлах ангийн сургуулиуд зөвхөн томоохон хот суурингуудад байдаг. Засаг захиргааны нэгж тус бүрийн хүн амын хэмжээнээс хамааран аймгийн төвийн сургууль нь сумын төвийн сургуулиас том, сум нь багийн төвийн сургуулиас том байх жишээтэй. Монгол Улс газарзүйн хувьд өргөн уудам, хүн амын нягтрал маш бага байдагтай уялдан хөдөө орон нутагт амьдарч буй хүүхдүүдэд зориулсан дотуур байртай сургуулиас боловсролын систем хамаарна. Бага сургуулийн хичээлийн жил нь сургалтын 34 долоо хоног, дунд сургууль 35 долоо хоног, ахлах сургууль 36 долоо хоногтой байдаг байна. Хичээлийн жил 9 дүгээр сард эхэлдэг бөгөөд 2 семестертэй.

#### **В. Сургуулийн өмнөх боловсрол**

18. Сургуулийн өмнөх боловсрол нь сайн дурын шинжтэй бөгөөд 2-оос дээш насны хүүхдийг хамруулдаг байна. Хувийн цэцэрлэгүүд нь төрийн өмчийн цэцэрлэгүүд болон бусад сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын хамтаар зэрэгцэн оршдог. 1995 онд батлагдсан Бага, Дунд боловсролын хуулиар улсын цэцэрлэгүүд нь голлон хүүхдийн танин мэдэхүй, бие, нийтэч сэтгэлгээг хөгжүүлэхийг зорьдог. Тэдгээрт хүүхдүүд эх хэл,

тоо, зураг, биеийн тамир, хөгжим, хөдөлгөөний хичээлүүд заалгадаг. Хүүхдүүд ихэнхдээ 7 хоногийн таван өдөр цэцэрлэгт явдаг бөгөөд хагас ажилладаг Хагас сайн өдөр хүүхдүүд өөр хэлбэрийн сургалтад хамрагддаг байна.<sup>48</sup>

19. Сүүлийн жилүүдэд сургуулийн өмнөх боловсролын ихэнх хэсгийг нь 2005 оны 4 дүгээр сард Эрүүл мэндийн сайд, Боловсрол Соёл, Шинжлэх ухааны Сайд нарын хамтарсан тушаалаар батлагдсан Бага насны хүүхдийг хөгжүүлэх Үндэсний цогц бодлогоор зохицуулах болсон байна. Энэхүү бодлого нь бага насны хүүхдийг хөгжүүлэх талбарт ажиллаж байгаа аливаа оролцогчдын хоорондын хамтын ажиллагаа, харилцан уялдааг бэхжүүлэх зорилготой юм. Уг бодлогоор хүүхдийг сургуульд ороход зохистой, үр өгөөжтэй бэлтгэхийн ач холбогдлыг онцолж гэр бүлийн гишүүд, төрийн болон хувийн хэвшлийнхэн гэх зэргээр хүүхдийн бага насны хөгжилд нөлөөлдөг бүх хүний янз бүрийн үүргийг тодруулжээ.<sup>49</sup>

20. 2007 онд сургуулийн өмнөх боловсролын тиймэрхүү байгууллагууд дахь нийт элсэлтийн харьцаа 58.1 хувь гэсэн тооцоо гарч байжээ.<sup>50</sup> Энэ тоонд тодорхой наснаас хамаарахгүй нийт хүүхдийн тоо багтсан нь заавал хамрагдах албагүй боловсролын энэ түвшин дэх онолын шинжтэй насны бүлэг дэх тооны хувь хэмжээ юм. Сүүлийн арван жилд Монгол Улс дахь элсэлтийн харьцаа нилээд өссөн болохыг тусгай илтгэгч тэмдэглэж байна. 1999 онд хүүхдүүдийн дөнгөж 25 хувь нь л сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байсан байна.<sup>51</sup> Тиймээс Монгол Улс 2007 онд 28 хувьтай байсан Төв Азийн бүс нутгийн дунджаас холдож 80–аас дээш хувьтай байдаг аж үйлдвэр өндөр хөгжсөн улс орнуудын боловсролын хувь харьцаа руу дөхөж байна.<sup>52</sup> Тусгай илтгэгч энэ эерэг хандлагыг сайшааж байгаа бөгөөд холбогдох эрх мэдэлтнүүд энэ байдлыг хэвээр хадгалахын төлөө шаардлагатай арга хэмжээг авна хэмээн найдаж байна.

### **Г. Бага боловсрол**

21. Бага боловсролыг заавал эзэмшүүлэхээр заасан бөгөөд одоогоор 6 жил үргэлжилдэг юм байна. 2002 онд Боловсролын хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр сургуульд орох насыг 8 байсныг 7 болгожээ. 2008 онд дахин өөрчилж 7–оос буулган 6 болгосон байна.

22. 1999–2000 оны хичээлийн жилд хуучин боловсролын тогтолцооны хүрээнд 128 сургууль зөвхөн бага боловсрол олгодог байжээ. Эдгээрийн ихэнх нь хөдөөгийн алслагдсан нутагт буюу сумдад байв. Тусгай илтгэгчийн авсан мэдээгээр найман жилийн хугацаатай үргэлжлэх бага болон суурь боловсрол хамтруулан олгодог 216 сургууль байсан ажээ. Бүрэн дунд 10 жилийн боловсрол олгодог 324 сургууль байсан байна.

23. Монголын бага сургуулийн сургалтын хөтөлбөр нь Монгол хэл, тоо, түүх нийгмийн ухаан, байгалийн ухаан, дуу хөгжим, зураг, биеийн тамирын хичээлүүдийг

<sup>48</sup> UNESCO and International Bureau of Education (IBE), World Data on Education – Mongolia, p. 8.

<sup>49</sup> Ibid., p. 9.

<sup>50</sup> UNESCO and Institute for Statistics, Global Education Digest 2009 – Comparing Education Statistics Across the World (Institute for Statistics, Montreal, 2009), p. 66.

<sup>51</sup> Ibid., p. 66.

<sup>52</sup> See: <http://huebler.blogspot.com/2005/07/pre-primary-education.html>; see also [http://www.uis.unesco.org/template/pdf/ged/2005/ged2005\\_en](http://www.uis.unesco.org/template/pdf/ged/2005/ged2005_en).

багтаадаг байна. Сурагчдыг нэгээс 4 дүгээр ангид дэвшин суралцаж үнэлгээг тасралтгүй үргэлжлэх байдлаар хийдэг. Бага ангиа төгсөхөд нь хүүхдүүдээс сургуулийн зүгээс шалгалт авна.<sup>53</sup>

24. Тусгай илтгэгчид мэдээлснээр онолын шинжтэй насны бүлэгт байх сурагчдын тоог нийт тооны хувиар тооцдог бага сургуулийн элсэлтийн хувь хэмжээ хамгийн сүүлд 2007 онд тооцоолоход 90 хувьтай байжээ.<sup>54</sup> Бага боловсролын түвшинд эрэгтэй эмэгтэй хүүхдийн статистик тооны хооронд үл ялиг зөрөө байв.

#### **Д. Дунд боловсрол**

25. 4 жил үргэлжилдэг суурь дунд боловсрол нь заавал эзэмших боловсролын сүүлийн шат юм. Хоёр дахь мянганы төгсгөлөөр хийсэн боловсролын шинэчлэлийн дараа суурь дунд боловсрол нь одоогоор 7–оос 10 дугаар ангийг хамардаг болжээ. (Ерөнхий боловсролын тогтолцоо нь одоо 12 жилийн тогтолцоонд шилжиж байгаа.) Бүрэн дунд боловсролын хугацаа нь 11, 12 дугаар ангийг хамарна. 9, 10, 11 дүгээр ангиа төгссөн хүүхэд техник мэргэжлийн болон тусгай мэргэжлийн сургуульд элсэж болдог.

26. Суурь болон бүрэн дунд боловсролын хөтөлбөрт аль алинд нь Монгол хэл, Монголын уран зохиол, гадаад хэл (англи, орос), тоо, байгалийн шинжлэх ухаан, газар зүй, биологи, физик, хими, түүх нийгмийн ухаан, дуу хөгжим, биеийн тамир, зургийн хичээлүүд ордог. Бага боловсролын түвшинд сурагчид сургуулиас авах шалгалтыг өгдөгийн адилаар, сурагчид суурь болон бүрэн дунд боловсролын төгсгөлөөр улсын шалгалт өгнө. Сурлагын амжилтыг анги болгонд дүгнэж улсын шалгалтыг А–F хүртэл үгсэн үнэлгээ өгөхөөс гадна хувьчилсан оноо бас өгнө.<sup>55</sup>

27. Тусгай илтгэгчид мэдээлснээр нийт элсэлтийн хувь хэмжээ дунд боловсролд бага боловсролынхоос доогуур байна. 2007 онд 12–15 насны сурагчдын 86.6 хувь нь дунд боловсролын сургууль элсэн орсон байна. Эмэгтэй хүүхэд, эрэгтэй хүүхдийг бодвол сургуульдаа үлдэх хандлагатай бөгөөд статистик мэдээгээр эмэгтэйчүүд элсэлтийн нийт хэмжээ 88.8 хувь байхад эрэгтэйчүүдийн элсэлтийн хувь хэмжээ 84.8 хувь байна.<sup>56</sup>

#### **Е. Дээд боловсрол**

28. Монгол Улсад дээд боловсрол олгодог сургуулиудын тоонд их дээд сургууль, коллеж, тусгай мэргэжлийн диплом олгодог сургуулиуд багтана. Бакалаврын зэргийн сургалт голчлон 4–5 жил үргэлжлэх бөгөөд доод тал нь 120 кредиттэй, хичээлийн нэг кредит бүхий дадлага ажлыг агуулдаг. Магистрын зэрэг авахын тулд дахин 1.5–2 жил сурах шаардлагатай. Докторын зэргийг авахын тулд дунджаар 3–4 жил сурна. Зарим коллеж 1–3 жил үргэлжлэх тусгай мэргэжил олгох сургалт явуулах бөгөөд дээд боловсролын диплом олгодог.

29. Төрийн мэдлийн олон их дээд сургууль оршдогоос тусгай илтгэгч Монгол Улсын Их Сургууль дээр зочилсон юм. Нийслэл хотод орших их сургуулиуд нь гол төлөв ангаах

---

<sup>53</sup> World Data on Education – Mongolia, p. 10.

<sup>54</sup> Global Education Digest 2009, p. 87.

<sup>55</sup> World Data on Education – Mongolia, p. 12.

<sup>56</sup> Global Education Digest 2009, p. 107.

ухаан, эрх зүй, хөдөө аж ахуй гэхчлэнгээр төрөлжсөн байдаг байна. Тусгай мэргэжил олгодог ихэнх коллеж нь төрийн өмчийнх. Эдгээр байгууллага сүүлийн жилүүдэд сургалтын агуулга, багш сонгох, оюутан элсүүлэх бодлогын хувьд ихээхэн бие даасан байдалтай болсон юм байна. Түүний дээр 1990–ээд оны боловсролын шинэчлэлийн үр дүнд тиймэрхүү сургуулиуд бий болсоны дараа олон тооны хувийн хэвшлийн дээд боловсролын байгууллага үйл ажиллагаа явуулах болжээ. 2009–2010 оны хичээлийн жилд хувийн хэвшлийн дээд боловсролын 99 сургуульд 64,000 орчим оюутан сурч байна хэмээн тусгай илтгэгчид мэдээлсэн байна.

30. Их сургууль болон өөр бусад төрлийн дээд боловсролын хөтөлбөрүүдэд элсэн орохын тулд ерөнхий боловсролын сургуулиа амжилттай дүүргэж гэрчилгээ авсан байх шаардлага тавьдаг. Гэхдээ дээд боловсролын бүх сургууль элсэлтийн шалгалт авдаг. Энэ нь жилд нэг удаа авдаг бөгөөд голдуу 6 дугаар сарын сүүлээр, эсвэл 7 дугаар сарын эхээр болдог. Тусгай илтгэгчийн сонссоноор 1993 оноос дээд боловсролын түвшинд сургалт үнэгүй байхаа больсон ажээ. Гэвч засгийн газар бага орлоготой айлын хүүхэд мөн сурлагын гарамгай амжилт гаргасан сурагчдад тэтгэлэг, зээл хэлбэрээр мөнгөн тусламж үзүүлдэг байна.

31. Дээд боловсролын сургуульд харьцангуй ихээр элсдэгээс Монголын нийгэм өргөн мэдлэг боловсролын үнэ цэнийг үнэлж үздэг нь харагдаж байна. Тусгай илтгэгчийн мэдсэнээр 2007 оны байдлаар 142,411 оюутан их дээд сургуульд сурч байсан байна.<sup>57</sup> Эдгээрээс 1,111 нь гадаадаас ирсэн орон орны оюутан байжээ.<sup>58</sup> 2007 оны нийт элсэлтийн хувь хэмжээ 48 хувь байсан нь бүс нутгийн дундаж болох 24 хувиас 2 дахин их байна. Эмэгтэй оюутны хувьд энэ хувь хэмжээ (60 орчим хувь) эрэгтэй оюутныхаас (40 орчим хувь) хамаагүй их байна.<sup>59</sup> Мөн 2007 онд Монгол Улсад 25,938 оюутан сургууль төгсжээ.<sup>60</sup>

## Ё. Тусгай боловсрол

32. Тусгай илтгэгчийн айлчлалын үеэр, аймгийн төв болон томоохон хотуудад биеийн болон оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тусгай боловсрол хэрэгтэй байгааг онцлон тэмдэглэж болно.<sup>61</sup> Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод 6 тусгай сургууль (9 жилийн 4 тусгай сургууль, 11 жилийн 2 тусгай сургууль) байдаг. Тусгай сургууль байдаггүй боловсролын дүүргүүдэд хөгжлийн бэрхшээлтэй сурагчид ерөнхий сурагчдын статистик тоонд ордоггүй гэж тусгай илтгэгчид мэдээлсэн байна.<sup>62</sup>

33. Хэдий тийм ч, Монгол Улсын Үндсэн хуульд эдгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг оролцуулан хүн бүрийн сурч боловсрох эрхийг баталгаажуулсан гэж Засгийн Газрын албан ёсны эх сурвалжаар онцолсон билээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол, сургалтын талаарх бодлогыг батлах, хэрэгжүүлэхийг улс хариуцдаг. Үүний

<sup>57</sup> Ibid., p. 130.

<sup>58</sup> Ibid., p. 138.

<sup>59</sup> Ibid., p. 130.

<sup>60</sup> Ibid., p. 150.

<sup>61</sup> Mercedes del Rosario, The Mongolian Drop Out Study (Mongolia Education Alliance, Ulaanbaatar, 2005), p. 7. Available from [http://pdc.ceu.hu/archive/00002501/01/DropOut\\_eng.pdf](http://pdc.ceu.hu/archive/00002501/01/DropOut_eng.pdf).

<sup>62</sup> Ibid., p. 40.

тулд Улс, Нөхөн сэргээх үндэсний төв байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусгай мэргэжлийн сургалтыг зохион байгуулсан юм. Мөн Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулж буй улсын 6 тусгай дунд сургууль байдаг. Түүнчлэн 2004/2005 оны хичээлийн жилд хараагүй хүүхдүүдэд зориулсан тусгай сургууль нээгджээ.<sup>63</sup>

### **Ж. Насанд хүрэгчдийн болон албан бус боловсрол**

34. Тусгай илтгэгчийн олж мэдсэнээр хуучин социалист тогтолцоонд үргэлжилсэн шат дараалан боловсрол олгох тухай ойлголт болон боловсрол олгох үйл ажиллагаа байгаагүй юм байна. Түүний тогтоосноор өнөөдөр Монгол Улсын 1.2 сая насанд хүрсэн хүн амын 100,000 орчим нь албан боловсролын ямар нэгэн хэлбэрт хамрагдсан байна.<sup>64</sup> Иргэдэд сургуулиас гадуур суралцах боломжийг 1991 онд Засгийн газар анх бий болгожээ. Хэдийгээр албан бус боловсролын хэрэгцээ шаардлагыг эрх зүйн хэмжээнд хуульчлан тогтоосон ч уг салбар нь бүтцийн хувьд төдийлөн бүрэн тогтворжоогүй байна. Албан Бус Боловсролын Төвийг улсын хэмжээний үйл ажиллагааг зохицуулахаар бий болгосон аж. 1997 онд Албан Бус Боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлжээ. Үүний дараа 2002 онд боловсрол эзэмших бусад боломжид чиглэсэн Алсын Зайн Боловсролын Хөтөлбөр эхэлсэн байна.

35. Албан бус боловсролын үндэсний хөтөлбөр Монгол Улсын хүн амын хэрэгцээ шаардлага сонирхолд хамгийн сайн нийцсэн албан бус сургалтын агуулга, хэлбэр, арга зүйг тодорхойлоход онцгойлон анхаарчээ. Тухайлбал уг хөтөлбөр бичиг үсэг тайлагдсан хувь хэмжээ болон ерөнхий боловсролын хүрэх түвшинг дээшлүүлэх, мэргэжлийн болон тусгай дадал чадварыг сайжруулахаар зорьж байна. Эдгээр зорилтод хүрэх ажилд яамд, төрийн бус байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, идэвхтэй оролцох юм. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллагын (ЮНЕСКО) Ази, Номхон далайн бүсийн боловсролыг хөгжүүлэх бодлоготой нягт уялдан зохицуулахаар урьдчилан тооцсон бөгөөд, харин албан бус боловсролын агуулгын хувьд улс орны өөрийн онцлогт тохируулан боловсруулах ажлыг Албан бус боловсролын төв гүйцэтгэх аж.<sup>65</sup>

36. Тусгай илтгэгчийн мэдсэнээр Монгол Улсын насанд хүрсэн хүн амын дундах боловсрол олох түвшин хангалтгүй байгаагийн байнга анзаарагдаж байгаа шалтгаан нь газар нутгийн хувь асар их алслагдмал байдлаас болоод хүртээмж тун тааруу байгаатай холбоотой ажээ. Тиймээс зайны боловсрол олгох Үндэсний хөтөлбөр нь боловсролын тэр дундаа насанд хүрэгчдийн бүх шатны боловсролд чиглэж байгаа нь ойлгомжтой юм. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны Яам албан бус боловсролын стратегийн удирдлага, зохицуулалт, хяналтын үүрэгтэй оролцож байна. Монгол Улс дахь ерөнхий боловсролын бүтэц, тогтолцоог харгалзан хөтөлбөрийг бүхэлд нь амжилттай хэрэгжүүлэхэд бусад засаг захиргааны нэгжүүд хувь нэмрээ оруулах

<sup>63</sup> Asia-Pacific Development Center on Disability, "Country Profile — Mongolia — Current Situation of Persons with Disabilities" (2009). Available from: <http://www.apcdproject.org/countryprofile/mongolia/situation.html>

<sup>64</sup> The Mongolian Drop Out Study, p. 18.

<sup>65</sup> Ibid., pp. 17–20.

шаардлагатай юм.<sup>66</sup> Тусгай мэргэжлийн сургалтад хамрагдаж байгаа хүмүүст янз бүрийн тусламж, тухайлбал тэтгэлэг, стипенд, дотуур байрны хөлс зэрэг дэмжлэг өгч байгаа бөгөөд үүгээрээ тэд суралцах хугацаандаа мөнгө төлөх шаардлагагүй болж байгаа хэмээн тусгай илтгэгчид мэдээлсэн байна. Хувийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдэд улсын төсвөөс дэмжлэг үзүүлж байгаа ажээ.

### 3. Боловсролын тогтолцооны санхүүжилт

37. Ихэнх улсад тохиолддогийн адилаар Монгол Улсад боловсролын санхүүжилт нь улсын төсвийн хуваарилалт, оюутны сургалтын төлбөр, эрдэм шинжилгээний тэтгэлэгээс бүрдэх бөгөөд сүүлийн хоёр эх үүсвэр нь ерөнхий боловсролоос дээших шатанд онцгой ач холбогдолтой юм. 1995 онд Боловсролын тухай хууль батлагдсанаар Монгол Улсын Засгийн газар нийт зардлынхаа 20 хувийг боловсролын салбарын санхүүжилтэд зориулсан.<sup>67</sup> Засгийн газрын албаны хүмүүсийн тусгай илтгэгчид мэдээлсэнээр 2008 онд засгийн газрын нийт төсвийн 24 хувийг боловсролын салбарт хуваарилсан нь тус улсын дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) 7.2 хувь болж байна. Тус улсын газар зүй, уур амьсгалын нөхцөл байдал болон жилийн нийт төсвийн 64 сая төгрөгийн бараг 20 хувийг<sup>68</sup> нь авчигдаг халаалтын зардал зэрэг нь боловсролын салбарын төсвийн хуваарилалтад тусдаг.

38. Монгол Улсад нүүрлэсэн санхүүгийн хямралын үр нөлөөгөөр эдгээр тоо хэмжээ өөрчлөгдөх шинжтэй байгаа бөгөөд цаашид ч өөрчлөгдөж магадгүй юм. Азийн Хөгжлийн Сангаас эдийн засаг, санхүүгийн хямралын үед боловсролын хүртээмж чанарыг хангах, боломжтой тохиолдолд сайжруулах үүднээс ядууст чиглэсэн Боловсрол–Санхүүгийн Хямралыг даван туулах төслийг эхлүүлэхээр ажиллаж байна. Энэ төслийн хүрээнд Азийн хөгжлийн Банкнаас 2009–2012 оны хооронд 17 сая хүртэл ам долларын хэмжээний тэтгэлгийг Монгол Улсад олгоод байна. Монгол Улсын Засгийн газар энэ санхүүжилт дээр 9.36 сая ам долларыг нэмэрлэжээ.<sup>69</sup>

39. Тусгай илтгэгчид мэдээлсэнээр 2002 оноос хойш өөрийн өвөрмөц зэрэгцээ тогтолцоотой нийслэл хотыг эс тооцвол улс орон даяар төвлөрүүлж ирсэн байна. Монгол Улс дахь боловсролын зардлын талаар тун ойлгомжтой ойлголт төсөөллийг 2005 оны Төрийн зардлын судалгаа болон түүний дараах Монгол Улс дахь боловсролын салбарын санхүүжилт Үр ашиг, тэгш байдал<sup>70</sup> хэмээх Дэлхийн банкны 2006 оны тайлангаас авч болно.

40. Эдгээр илтгэлүүдэд дурдсанаар Монгол Улсын сургуулиудын санхүүжилтийг санхүүжилтийн тодорхой томъёоллын дагуу төлөвлөж, хуваарилдаг байна. Энэ томъёогоор хувьсах болон тогтмол зардлыг ялгана. Хувьсах зардал нь хичээлийн жилд авахаар тооцоолсон элсэлтийн тоо хэмжээнээс хамаардаг бол тогтмол зардал нь өмнөх зардал дээр үндэслэдэг аж. Тухайн сургуулийн авах санхүүжилтийн хэмжээ нь хөдөө,

<sup>66</sup> Ibid., pp. 21–22.

<sup>67</sup> World Data on Education – Mongolia, p. 7.

<sup>68</sup> Report No. 36979–MN, Washington D.C., World Bank, 2006, p. 43.

<sup>69</sup> Asian Development Bank, Proposed Asian Development Fund Grant – Mongolia: Education for the Poor – Financial Crisis Response Project, Project No. 43127 (2009), p. 6.

<sup>70</sup> See Public Financing of Education in Mongolia.

хотын аль болох, суралцагчдын тоо, сургуулийн төрөл зэргээс хамаарна. Аймгууд авсан нийт санхүүжилтээ жижиг сургуулиуддаа нэмэлт олгохын тулд дахин хуваарилах тохиолдол гардаг.<sup>71</sup>

41 Боловсролын санхүүжилттэй холбоотойгоор Монгол Улсын нэг өвөрмөц онцлог нь багш нарын цалин хөлсний тогтолцоо юм. Багшийн цалин хөлс үндсэн цалин, нэмэгдэл, урамшуулал гэсэн гурван үндсэн хэсгээс бүрдэнэ. Үндсэн цалин нь ажлын туршлагаас голчлон анхаарч байхад нэмэгдэл нь ангийн хэмжээ, алслагдмал байршил гэх мэтчилэн олон нөхцөл шалтгаанаас хамаардаг. 2010 оны эхний байдлаар дунд сургуулийн багшийн дундаж цалин сарын 180 ам долларт хүрсэн байна. Урамшуулал олгох болон цалин бууруулах шалгуур нь тусгай илтгэгчид тодорхойгүй байлаа. 2005 оны Төрийн зардлын судалгаанаас харвал хотын сургуулийн багш нар хөдөөний сургуулийн багш нараас илүү авдаг бөгөөд энэ нь голчлон хичээл заах ангийн тоо хэмжээнээс шалтгаалдаг байна.<sup>72</sup>

#### **IV. Боловсролын салбарын зэрэг туршлага**

##### **А. Элсэлтийн өндөр хувь хэмжээ, боловсролыг үнэлэх нийгмийн үнэлэмж**

42. Хэдийгээр цаашид анхаарч сайжруулах шаардлагатай зүйл байгаа нь илт боловч Монгол Улс дахь сургуульд элсэх хувь хэмжээ, тэр дундаа бага, болон дунд ангид элсэх хувь хэмжээ маш дээгүүр байгаа нь тун өндөр сэтгэгдэл төрүүллээ. Сүүлийн байдлаар 2007 онд нийт бага ангийн элсэлтийн хувь хэмжээ охид хөвгүүд нийлээд 92.7 хувь байлаа. Дунд ангийн элсэлт 86.6 хувь байсан нь бага ангитай харьцуулбал доогуур боловч харьцангуй өндөр хэмжээ юм. Энэ шатанд эмэгтэй хүүхдийн элсэлтийн хувь эрэгтэйчүүдээс илүү өндөр байх хандлагатай байна.

43. Монгол Улсад бүх нийтийн бодитой боловсрол олгоход учрах томоохон саадуудыг амжилттай даван туулж чадах нь харагдлаа. Эрс тэс уур амьсгалтай нөхцөлд хамгийн таруу суурьшилтай оронд аж төрдөг хэдий ч Монгол хүүхдийн дийлэнх олонх нь бага, дунд сургууль сурах бололцоо, хүртээмжтэй байна.

44. Сургуулийн сургалтын хөтөлбөрт орсон саяхны шинэчлэлтийн хамтаар эдгээр элсэлтийн өндөр хувь хэмжээнээс тусгай илтгэгч боловсролын үнэ цэнийг Монголын нийгэм дээд хэмжээнд ойлгож мэдэрдэг, энэ хандлага нь цаашид ч ихсэх шинжтэй гэж дүгнэж байна. 2005–2006 оны хичээлийн жилээс Монгол хүүхдүүд 7 наснаасаа сургуульд элсэж эхэлсэн. 2008–2009 оны хичээлийн жилд элсэх нас 6 нас болсон. Эдгээр өөрчлөлт нь эрт бага насандаа сургуульд сурсны үр шим хүртэх боломж олгож байна.

45. Боловсролыг нийгэмд өндөр хэмжээнд үнэлж байгаа нь дээд боловсролын түвшинд ч тусгалаа олсон нь харагдаж байна. Их, дээд сургуульд элсэх нийт хувь 2007 онд 48 хувьд хүрсэн нь бүс нутгийн дунджаас хоёр дахин их байна. 1990–ээд оны үед боловсролын тогтолцоог журамладаг хууль, тогтоомжуудад орсон өөрчлөлтийн үр дүнд төрийн мэдлийн их дээд сургуулиудаас гадна шинэ хувийн өмчлөлтэй их, дээд

---

<sup>71</sup> Public Financing of Education in Mongolia. pp. ii–iv.

<sup>72</sup> Ibid., p. 48.

сургуулиуд бий болсон нь эерэг өөрчлөлт гэж тусгай илтгэгч үзлээ. Дээд боловсролын тогтолцоонд сургалтын төлбөрийг нэвтрүүлсэн нь ихэнх хөгжингүй улс оронд нийтлэг туршлага боловч ялангуяа Монгол оронд нүүрлээд байгаа эдийн засгийн уналтын одоогийн нөхцөлд хэт нэмэгдэж магадгүйг тусгай илтгэгч анхааруулж байна.

### **Б. Нүүдлийн гэр цэцэрлэг ба үдийн цай**

46. Тусгай илтгэгчийн мэдсэнээр Монгол Улсад хүн амын 40 орчим хувь нь хөдөө аж төрж, хөдөөний айлын 2–6 насны хүүхдийн 42 хувь нь л сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг авч чаддаг ажээ. Гэтэл 2008 онд сургуулийн өмнөх боловсрол олгох газруудын тоо хэмжээ 73.1 хувьд хүрсэн байна.

47. Хэдий тийм ч сургуулийн өмнөх боловсролын хүртээмж, чанарыг сайжруулах өвөрмөц санаачилга гаргаж, нүүдлийн гэр цэцэрлэгийн хөтөлбөрийг бий болгох замаар хөдөө нутгууд дахь цэцэрлэгийн хүртээмж, үйлчилгээг нэмэгдүүлэх Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яамны бүтээлч санааг сонсоход таатай байлаа. Энэхүү хөтөлбөрт ЮНИСЕФ болон төрийн бус байгууллагууд дэмжлэг үзүүлж байгаа юм. 2008 онд энэ санаачилгын үр дүнд 21 алслагдсан сум 38 гэр цэцэрлэг байгуулж, сургуулийн өмнөх боловсролын хүртээмж чанарыг дээшлүүлсэн бол Education for All Fast Track Initiative төслийн хүрээнд өөр 50 суманд 50 гэр цэцэрлэг байгуулжээ.

48. Үүнээс гадна боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулахаар алслагдмал нутагт ажиллаж байгаа нүүдлийн цэцэрлэгийн багш нарт зориулсан тусгай сургалтууд зохион байгуулсны заримыг ЮНИСЕФ-ийн дэмжлэгтэйгээр явуулсан байна. Хөдөөний айлуудтай ойрхон байдгаараа нүүдлийн цэцэрлэгийн багш нарт эцэг эхчүүдтэй шууд харьцах боломж илүү байдгаараа хүүхдийн бага насны эхэн үеийнх нь талаар чухал мэдээллүүдийг олж авч чаддаг ажээ.

49. Нүүдлийн цэцэрлэг, явуулын багш нар алслагдмал газар амьдардаг хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол олгоход чухал үүрэгтэй болох нь харагдсан. Гэхдээ улс орны хэмжээгээр хамрах байдал нь хязгаарлагдмал хэвээр л байна. Тиймээс тусгай илтгэгч балчир насны хүүхдийн хөгжил болон гэр бүлийн доторх сургуульд бэлтгэлийг дэмжихийн тулд нүүдлийн гэр цэцэрлэгүүдийн чадавхыг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзлээ.

### **В. Үндэсний цөөнхийн боловсрол болон бусад бүтээлч санаачилга**

50. Тусгай илтгэгч Ховд сумын сургуульд зочилсон бөгөөд тус сургуулийн сурагчид, багш нар, албан хаагчид нь казакууд байлаа. Казах нь Монгол Улс дахь голлох үндэсний цөөнхийн бүлэг бөгөөд голлон тус орны баруун хэсэгт суудаг юм. Энэ ястан бага ангидаа хоёр хэлээр боловсрол олж авч байгааг, мөн Засгийн газар казак хэлний сургалтын хөтөлбөр, сурах бичгийг боловсруулахаар идэвхтэй ажиллаж байгааг тэмдэглэхэд таатай байна. Мөн хэдийгээр тусгай илтгэгчийн очсон суманд нь тохиогоогүй боловч бүр баруун хэсэгт Баян-Өлгий аймагт казак хүүхдүүд, өсвөр насныхан дунд боловсролоо эх хэлээрээ үргэлжлүүлэх боломжтой юм байна.

51. Мөн Тусгай илтгэгчид мэдээлснээр тус орны хойт хэсгийн уулархаг нутагт суух Тува ястанд хүргэхээр мөн төстэй хөтөлбөр ЮНИСЕФ хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа



ажээ. Ийнхүү Засгийн газрын зүгээс цөөнхийн боловсролын тусгай хэрэгцээнд нээлттэй хандаж (мөн хүн амын олонх хүлээн зөвшөөрч) байгаа нь цаашид хөгжүүлж, хамрах хүрээг нь өргөжүүлбэл зохих сайхан туршлага болж байна.

52. Үүнээс гадна Тусгай илтгэгч сургуульд суугаагүй буюу сургууль завсардсан, өдөр тутмын амьдралд эсвэл хөдөлмөрийн зах зээл дээр ажиллах дадал чадвар эзэмшээгүй хүмүүст суралцах боломж олгоход чиглэсэн албан бус боловсролын төвүүдээр зочилсон юм. Албан бус боловсролыг дэмжих хөтөлбөр 1995 онд хэрэгжиж эхэлсэн бөгөөд Албан бус боловсролын төвийг Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яамны дэргэд албан бус боловсролтой холбоотой үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохицуулах ажлыг хариуцуулахаар байгуулжээ. Тусгай илтгэгчид хөдөө орон нутагт явуулын багш ажиллуулахаас гадна радио болон хэвлэмэл материал ашиглан насанд хүрэгсдэд зориулсан боловсролын хөтөлбөрүүд явуулахад чиглэсэн тусгай хөтөлбөрүүдийн талаар мэдээллэсэн юм. Тиймэрхүү хөтөлбөр болон бусад санаачилга нь гадны доноруудын тусламжид ихээхэн найдлага тавьдаг байна.

53. Эцэст нь Тусгай илтгэгчид өгсөн мэдээлэлд дурдсанаар экологийн боловсрол дутмаг байгаа нь байгаль орчин доройтоход нөлөөлж байгаагаас залуу үеийг байгаль хамгаалахад сургахад чиглэсэн бүтээлч санаачилгууд гарч байна. Олон нийтийн дунд экологийн боловсрол, мэдлэг ойлголтыг сэргээх чармайлтын хүрээнд Монгол Улсын Засгийн газар 1997 онд Нийтийн Экологийн Боловсролын Үндэсний Хөтөлбөрийг баталжээ. Уг хөтөлбөрт дунд сургуулийн сурагчдын дунд экологийн сургалт явуулах ажил орсон байна. Швейцарийн Хөгжил, Хамтын Ажиллагааны Агентлаг зэрэг гадны түншүүдийн тусламжтайгаар хүүхэд багачуудад танхимын болон танхимын бус сургалтаар байгаль, хүрээлэн буй орчин болон тэдний өдөр тутмын амьдралд ямар харилцан нөлөөтэй байдаг талаар илүү ихийг олж мэдэхэд сургадаг байна. Туршилтын төслөөр 20 багш (голлон биологи болон газар зүй заадаг) сургалтын хөтөлбөр боловсруулах ажил болон түүнийгээ хэрэглэх сургалтад хамрагджээ.

## **V. Эдийн засгийн бэрхшээл**

### **A. Сургууль завсардалт, баталгаатай статистик мэдээллийн хангалтгүй байдал**

54. Монгол Улсын хүн амын бараг 35 хувь нь 18-аас доош насныхан ба ÷ нь 10-аас 19 насныхан байдаг гэсэн тооцоо байна. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг унаж, 1990-ээд оны үед зах зээлийн эдийн засаг руу хурдацтай шилжилт хийснээс хойш, тус улсад ядуурал газар авч, ажилгүйдэл ихсэн маш их хэмжээний өрийн дарамт үүссэн байна. Боловсролын салбарт ч бас шинэ тутам асуудлууд ажиглагдаж байгаагийн дотор сургуулийн нөхцөл байдал муудсан, хичээл заах аргын болон сурлагын чанар доройтсон (ялангуяа хөдөө орон нутгийн сургуулиудад), хүүхдүүд сургуулиас гадуур амралт чөлөөт цагаа зохисгүй байдлаар өнгөрөөх болсон сургууль завсардалтын түвшин өссөн зэрэг орно.

55. Тусгай илтгэгчийн авсан мэдээллээр сургууль завсардалт маш өндөр, тэр дундаа тийм залуучуудын орны хувьд бол тун өндөр хувь хэмжээнд хүрсэн байна. Сургууль завсардалт эдийн засгийн шилжилтийн эхний жилүүдэд анхаарал татахуйцаар өссөн

гэж тооцоолдог бөгөөд түүнээс хойш зугуухан буурч байгаа аж. Гэвч тусгай илтгэгч энэ үзэгдлийн цар хэмжээний талаар тодорхой дүр зураг болчихоор статистикийн баталгаатай баримт олж чадаагүй болно. Цаашилбал түүнд сургууль завсардалтын талаарх албан ёсны тоо баримтууд нь хоорондоо зөрөөтэй, төөрөлдмөөр гэж мэдээлсэн байна. Гэсэн хэдий ч 2001 онд хөдөө орон нутгийн хүүхдүүдийн 15 орчим хувь нь хөдөө аж ахуйн салбарт хөдөлмөр эрхэлсний улмаас (мал малласан) сургуульд сураагүй гэж тооцоолсон бол хотуудад энэ статистик 8 хувьтай байжээ.

56. Тусгай илтгэгчид мэдээлсэн өөр нэг зүйл бол тэдгээр завсардагчдын олонх нь хөвгүүд ажээ. Эрэгтэй хүүхэд, эмэгтэй хүүхдээс олноороо сургуулиас завсардсан нь хачирхмаар үзэгдэл. Тусгай илтгэгчид мэдээлснээр, ялангуяа хөдөө орон нутагт айл өрх хөвгүүдийг сургуульд сургаснаас аж ахуй дээр байлгах нь эдийн засгийн хувьд үр ашигтай гэж үздэг аж. Илтгэл тайлангуудаас харвал 2001 онд сургуульд суралцсан хувь хэмжээ хот суурин газар 7–19 насныхны дунд эрэгтэйчүүдийнх нь 53.6, эмэгтэйчүүдийнх 59.6 хувь байсан байхад хөдөө орон нутагт эрэгтэйчүүдийнх 32.8 хувь, эмэгтэйчүүдийнх 39.3 хувь байжээ. Мөн сургууль завсардах гэдэгт тодорхой ойлголт байхгүй байгаа энэ талаар найдвартай тоо баримт гарахгүй байх үндэс болж байна. Тусгай илтгэгч мөн боловсрол олгох загварын бүтцэд гарсан сүүлийн үеийн өөрчлөлтүүд, 1990 онд 6+2+2 байсан бол 1992 онд 3+5+2, 1998 онд 4+4+2, хамгийн сүүлд 6+4+2 болсон зэрэг нь сурагчид, эцэг эхчүүдэд ойлгомжгүй байсан зэргээс сургуульд суух идэвхид нөлөөлж байсан гэдгийг тэмдэглэж байна.

57. Тийм учраас тусгай илтгэгч сургууль завсардах гэдэг ойлголт, нэр томъёогоо тодорхойлж, түүний үр дагаварт анхаарал хандуулахыг зөвлөж байна. Мөн мэдээлэл, баримт, ирц бүртгэлийг хэрхэн хөтөлж байгааг тэр дундаа хөдөө орон нутгийн сургуульд бүртгэл мэдээлэл ямар байдалтай байгааг анхаарах шаардлагатай. Багш нар, нийгмийн ажилтнуудыг тогтсон, нэг жигд байдлаар ирц хөтлөх болон бусад мэдээ баримт хөтлөх тал дээр илүү сайн сургах хэрэгтэй байна.

58. Тусгай илтгэгч мөн дагаж биелүүлээгүйд хариуцлага тооцох заалт, механизм байхгүйгээс болоод Монгол Улсад заавал эзэмшүүлэх боловсролыг олгох тал дээр хүчин чармайлт тавьдаггүй болохыг онцолж байна. Тийм байдлаар эцэг эхчүүд хүүхдээ сургуулиас ямарваа шалтгаанаар гаргахад амархан байдаг. Үүнд Монголын хөдөөгийн нүүдлийн уламжлал, улс орны байгаль цаг уурын хүнд нөхцөл, зарим суурин газрын алслагдмал байдал зэрэг хүч нэмдэг.

### **Б. Сургуулийн дэд бүтэц хөдөө орон нутаг дахь усны хүрэлцээ, ариун цэвэр, дотуур байрны нөхцөл байдал**

59. Хөдөө орон нутгийн дийлэнх хэсэгт нь хүн амын нягтшил бага, нүүдлээр амьдрах хэв маягтай зэргээс, сургуулийн дотуур байр Монголын боловсролд ямар чухал үүрэгтэйг харж болно. 2008–2009 оны хичээлийн жилд 492 төрийн, 10 хувийн дотуур байртай сургуульд 42,086 сурагч (нийт сурагчдын 8 орчим хувь) элссэний 36,808 нь малчдын хүүхэд байв. Хөдөөгийн жижиг сургуулиуд болон дотуур байртай сургуулиудыг засварлах зардал өртөг өндөр болохыг ойлгохын сацуу тусгай илтгэгч тэдгээр боловсролын байгууллагуудын ихэнх нь цаг үеэ өнгөрөөж хуучирсан, засвар, үйлчилгээ зайлшгүй

шаардлагатай болохыг өөрийн нүдээр харж явсан юм. Хөрөнгө оруулалт ихээхэн удаж байж ирдэг алслагдсан нутгуудад энэ байдал бүр хурцаар тавигдаж байна. Хот хөдөөгийн сургуулиудын ялгаа тэнгэр газар шиг, Засгийн газар яаралтай арга хэмжээ авах шаардлагатай байна.

60. Мөн тусгай илтгэгчийн тэмдэглэж байгаа нэг зүйл бол бага, дунд сургуулиудын дэд бүтцийн байгууламжууд үеэ өнгөрөөж хуучирсан байх хандлагатай, ихэнх нь засвар авахаа больсон, мөн засвар үйлчилгээ, сэргээн засварлах төсвийн зарцуулалт нь бүхэлдээ зохисгүй байлаа. Тусгай илтгэгч Засгийн газар нь илүү чанартай тоног төхөөрөмж, сургалтын, заах арга зүйн сайн материаллаг бааз, сайн чанарын шинжилгээ судалгааны тоног төхөөрөмж, номын санд санхүүжилт хийх шаардлагатай гэж үзэж байна. Мөн хөдөө орон нутгийн сургуулиудын эрүүл ахуй туйлын тааруухан, олон байгууламжид ундны ус, мөн ариун цэврийн хэрэгслийн зохистой хэрэглээ дутагдалтай байгаа зэргээс сурагч, багш нарын эрүүл мэндэд халтай байгаа нь тусгай илтгэгчийн анхаарлыг татсан нэг зүйл байлаа.

61. Хамгийн хачирхалтай нь ачаалал хэтэрсэн олон сургууль, дотуур байранд ариун цэврийн өрөө байхгүй, хувийн ариун цэврээ наад захын хэмжээнд сахихад сурагчдад хэцүүхэн байдаг байна. Эдгээр нөхцөл байдал нь сурагчдын мөн цаашилбал сургуульд ажиллаж байгаа багш, ажилчдын эрүүл мэндэд ноцтой аюул занал учруулж байна. Мөн хөдөө орон нутгийн дотуур байрны эрүүл ахуйн ийм тааруухан байдал нь сурагч сургуулиас гарах, завсардах нэг хүчин зүйл болж байгаа нь олон эцэг эх хүүхдээ ариун цэврийг зохистой хэмжээнд сахиулаагүй сургуульд, ялангуяа заавал олгох бага боловсролын эхний жилд явуулахыг хүсэхгүй байгаагаас харахад ойлгомжтой юм.

62. Тусгай илтгэгч сургуулиудын эрүүл ахуйг зохистой хэмжээнд хангахгүй байгаа нь сурч боловсрох эрхэд ноцтойгоор халдаж байгаа явдал болохыг Засгийн газарт анхааруулахыг хүсч байна. Тэрээр ундны цэврээ ус болон эрүүл ахуй хүртээмжтэй холбоотой хүний эрхийг хэрэгжүүлэх асуудлаарх хөндлөнгийн шинжээч ариун цэврийг зохистой хэмжээнд хангаагүйгээс болж өвчин дэгдэх нь хүүхэд өвдөж тэдний суралцах чадварт сөргөөр нөлөөлж байсныг тэмдэглэсэн болохыг сануулж байна.<sup>73</sup>

63. Гэхдээ Тусгай илтгэгч сургууль нь хүүхдүүдэд эрүүл мэнд, ариун цэврийн холбогдолтой дадал чадварыг оролцуулаад ашигтай амьдрах ухаан, дадал чадвараа хөгжүүлэхэд нь тусалж өөрчлөлт эхлүүлэхийн хувьд тодорхойлогч хүчин зүйл болдогийг цохон тэмдэглэхийг хүсч байна. Сургуульд сурч авсан эрүүл ахуйн зан төлөв эерэг дадал, зуршил суухад нөлөөлж болдог. Багш нар нь зөвхөн хүүхдүүдэд төдийгүй ойр тойрныхон олон нийтэд хүртэл үлгэр жишээ үзүүлж чаддаг. Нөгөөтэйгүүр хүүхдүүд ихэнхдээ томчууд, дүү нар гэх зэрэг гэр бүлийнхээ бусад гишүүдэд нөлөөлж тэр хэрээрээ ариун цэврийн дадал зуршилд илүү нийтлэг, нийтийн шинжтэй өөрчлөлт гарахад хүргэдэг.

#### **В. Хот руу чиглэсэн шилжилт нүүдэл хийгээд ачаалал нь хэтэрсэн хотын сургуулиуд**

64. Хөдөө нутгаас хот, төв суурин газар руу, тэр дундаа нийслэл болон түүний захын дүүрэг рүү чиглэсэн дотоод шилжилт нүүдэл хэмээх үзэгдэл 1990–ээд он, төвлөрсөн

---

<sup>73</sup> See A/HRC/12/24, paras. 30–32; see also Committee on the Rights of the Child, general comment No. 4 (2003).

төлөвлөгөөт эдийн засаг задран унаснаас хойш үүсэж хүчээ авсан байна. Тийм нүүдэл нь 2008 онд санхүүгийн хямрал тус улсад нүүрлэснээр улам өндөр хэмжээнд хүрчээ. Хэдийгээр санхүүгийн хямралын үр дагаварын мөн чанарыг тогтоочихоогүй байгаа ч тусгай илтгэгчид голлох бараа бүтээгдэхүүний болон хичээлийн хэрэглэгдэхүүний үнэ хөдөөд хотынхоос илүүтэй өсч байсан талаар мэдээлжээ. Зах зээлийн эдийн засагт орох шилжилтээс шалтгаалан ажилгүйдэл нэмэгдэн, мал аж ахуйн салбарын бүтээмж, үр ашиг буурч, үйлчилгээний салбар ноёлох болсноор хөдөөгийн хүн амын аж амьдралд цохилт болсон байна.

65. Энэ бүх хүчин зүйлс аймгийн төвүүд рүү дотогшоо чиглэсэн нүүдлийг эхлүүлсэн нь эргээд мөн хөдөө нь хотжисон шинэ хүн амыг бий болгосон байна. Улаанбаатар болон ойр орчмынх нь газрууд дотогшоо чиглэсэн нүүдэлд ихээхэн өртөж хүн ам нь сүүлийн хэдхэн жилд хоёр дахин өсчээ. Түүний хажуугаар хөдөө нутгууд цагтаа тогтвортой байсан хүн амаа алдаж байна. Хотууд руу чиглэсэн их нүүдэл нь хот, суурин газрын сургуулийн үйлчилгээний эрэлтийг ихээхэн хэмжээнд ихэсгэснээр ийнхүү боловсролын салбарт шинэ хүндрэл бэрхшээлүүдийг авчраад байна. Хөдөөний сургуулийн зарим нь хамрах газраас нь гадагшаа чиглэсэн урсгалаас болоод хүчин чадлаасаа доогуур ачаалалтай ажиллаж байгаа ажээ.

66. Эдгээрээс гадна хөдөөнөөс хот руу чиглэсэн их нүүдэл нь боловсролын салбарын эрх барих хүмүүст өөр бусад хүндрэл учруулж байгааг Тусгай илтгэгч ажигласан болно. Алслагдсан хөдөө нутгийн сургуулиуд улам бүр буурч байгаа элсэлт, улам бүр өсөх нэг хүнд оногдох зардлынхаа асуудлыг шийдэх гэж тэмцэлдэж байхад хот суурин газар, тухайлан хэлбэл Улаанбаатар түүний шууд залгаа орчинд дотоодын шилжилт хөдөлгөөн сургуулийн дэд бүтцэд ихээхэн хэмжээний дарамт үүсгээд байна. Олон сургууль одоо хоёр ээлжээр, зарим нь бүр гурван ээлжээр ажиллаж, нэг багшид оногдох сурагчдын тооны харьцаа тогтмол өссөөр байна.

67. Тусгай илтгэгч энэхүү хотын сургуулиудын ачаалал хэт ихэссэн байдал ба үүнээс шалтгаалан сурах орчинд гарч болозошгүй үр дагаварт санаа зовж байна. Энэ нь ангиуд дахь хязгаарлагдмал зай талбай, цөөхөн тооны хичээл гадуурх үйл ажиллагаатай хавсраад зөвхөн хүчин чадлаас төдийгүй мөн уур амьсгалын нөхцөл байдлаас шалтгаалан цаашид суралцах эерэг орчинд сөргөөр нөлөөлөх юм. Тусгай илтгэгч Засгийн газарт хот болон хотжиж байгаа газруудад шинээр сургуулийн байр, байшин барихыг эн тэргүүнд тавихыг зөвлөж байна.

### **Г. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол**

68. Тусгай илтгэгчид мэдээлснээр боловсролын системд элсэн орсон 23,969 сурагч тусгай боловсролын хэрэгцээ бүхий бие эрхтний ямар нэг согогтой байна. 10,921 сурагч харааны согогтой (6,337 нь эмэгтэй) бол, 1,862 хүүхэд сэтгэцийн согогтой, 4,529 нь сонсголын бэрхшээлтэй, 2,575 нь янз бүрийн хөгжлийн бэрхшээлтэй байна. Улаанбаатар хотын 29 дүгээр сургууль нь Улаанбаатарын бусад таван тусгай сургуульдаа сургалтын хөтөлбөр, сурах бичиг, материал боловсруулж өгөх эрх бүхий тэргүүний тусгай сургууль юм. Монгол Улсад тусгай сургалтын хэрэгцээг хангах 200 орчим багш бий гэсэн тооцоо байдаг. 1994 онд Багшийн сургууль тусгай боловсролын багш нар бэлтгэх факультет

байгуулжээ.

69. Гэвч нилээд санаа зовоож байгаа нэг зүйл бол хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад боловсрол олгох боломж, бололцоо бодит байдалд хэрэгжихэд тун хол байгааг тусгай илтгэгч цохож байна. Тусгай илтгэгчийн ажиглаж мэдсэнээр эдгээр сурагчдыг албан боловсролын бүтцэд биш албан бус боловсролын төвүүдэд ялгасан байна. Хэдийгээр тусгай илтгэгч хөгжлийн хөнгөн бэрхшээлтэй сурагчдыг албан боловсролын тогтолцоонд байгааг тогтоосон ч багш нар нь их төлөв тусгай боловсролын хэрэгцээ шаардлагад нийцсэн чадвар, чадавх байхгүй болох нь ажиглагджээ.

70. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаар найдвартай статистик тоо баримт байхгүй байгаа нь тусгай илтгэгчийн санааг зовоосон асуудал байлаа. Энэ байдал нь ийм хүмүүс хэд хэчнээн хаана байгааг тогтооход саадтай төдийгүй, тэдний хэрэгцээнд чиглэсэн төрийн бодлого боловсруулахад саад болж цаашид ялгаварлан гадуурхах явдлыг ихэсгэж байгаа юм. Тусгай илтгэгч Засгийн газрыг хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг энгийн тогтолцоонд хамруулах боломж олгох боловсролын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх талаар дорвитой алхам хийхийг зөвлөж, Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид нэгдсэн хийгээд, энэ талаар үүрэг хүлээсэн болохыг сануулж байна. Тэдгээр хөтөлбөр нь сургуулиудад бие организмын хувьд тэнцвэржүүлэх арга хэмжээ авах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг зорчих бололцоогоор хангаж, чанартай боловсрол тэгш олгох үүднээс алхам алхамаар сургалтын хөтөлбөр, багш нарын сургалтыг энэ тал руу ойртуулах зорилготой байвал зохино.

#### **Д. Хүний эрхийн соёлын дутагдалтай байдал**

71. Энэ томилолтын үеэр олон уулзалтад оролцож, олон сургууль, боловсролын байгууллагаар орж явахдаа тусгай илтгэгч эмэгтэйчүүд улс орны төрийн хэрэгт тун бага оролцдог болохыг ажиглалаа. Мөн Монгол дахь боловсролын гол шинжүүдийн нэг нь эмэгтэй хүйсийн төлөөлөл зохистой биш хувь хэмжээнд байгаа болон үүгээрээ боловсролын тогтолцоонд эмэгтэйчүүдийн давамгайл байдлын талаар яриа гардаг зэрэг хүйсэд суурилсан тодорхой хэвшил амь бөхтэй байгаа нь ажиглагдлаа.

72. Мөн тусгай илтгэгч боловсролын тогтолцоон дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь хэмжээ хэт их байгаа нь төрийн хэрэг дэх эмэгтэйчүүдийн оролцоо бага байгаатай зөрчилдөж байгааг тэмдэглэлээ.

73. Мөн түүнчлэн тусгай илтгэгч дан ганц сургуулийн орчинд төдийгүй нийт Монгол Улсын хүн амын дундах уламжлалт хүйсэнд тулгуурласан хандлагаасаа салж, хүний эрхийн соёлыг бий болгохын ач холбогдолыг онцлохыг хүсч байна. Тийм учраас боловсролын хөтөлбөрүүд дэх хүний эрхийн алсын харааг бэхжүүлэх шаардлага их байна. Хэдийгээр Хичээлийн хөтөлбөрийн зарим хэсэг зарим нэг хүний эрхийг тусгасан байх боловч тэдгээр нь тайлбарласан өнгөц шинжтэй, нийгэм судлал, түүх, иргэний боловсрол гэсэн гурван хичээлээр л хязгаарлагдаж байна. Тусгай илтгэгч мөн Монгол Улсын Боловсролын Их Сургууль хэдийгээр хязгаарлагдмал нөөц бололцоотой ч энэ талаар үнэлүүштэй санаачлага чармайлт гаргаж байгааг дурдахыг хүсч байна. Монгол хэл дээр хүний эрхийн талаарх зохиол бүтээл дутмаг байгаа нь олон улсын хамтын нийгэмлэг,

Монгол дээр ном, зохиол орчуулах ажлыг дэмжиж, санхүүжүүлэхэд Нэгдсэн Үндэстний Байгууллагын харьяа байгууллагуудын анхаарлыг хандуулах шаардлагатай асуудал мөн.

74. Тусгай илтгэгч мөн саяхны урт хугацааны хүний эрхийн ойлголтын талаарх тайландаа дурдсан ажиглалтаа эргэн сануулж хүний эрхийн сэдэв агуулга руу аль болох ойртож сурах шаардлагатай байгааг онцлон, энэ нь ямарваа ялгаварлал, гадуурхал, ад шоо үзэх хэлбэр байхгүй нийгэмд дэвшиж, дэлхий нийтэд хүний эрхийн соёл хэрэгжихэд чухал ач холбогдолтой болохыг тэмдэглэж байна.<sup>74</sup>

## VI. Дүгнэлт, зөвлөмж

75. Тусгай илтгэгч Монгол Улсын Засгийн газар, иргэний нийгэм, болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын харьяа байгууллагуудад энэ томилолт амжилттай болоход бүх чадлаараа дэмжлэг үзүүлсэнд талархал илэрхийлэхийг хүсч байна. Мөн хийсэн уулзалтуудын үеэр байсан илэн далангүй уур амьсгалд сэтгэл хангалуун байсан бөгөөд харилцагчдынх нь өөрсөддөө шүүмжлэлтэй хандаж байсан нь таатай сэтгэгдэл төрүүлж байлаа. Тусгай илтгэгч Засгийн газарт улс орны зарим тодорхой нөхцөл байдал, тулгарсан бэрхшээлийг үл харгалзан хүн бүрт боловсрол олгох гэж нэгэн сэтгэлээр зүтгэж байгааг нь сануулахын зэрэгцээ хүний эрх бол хөгжилд хүргэх гүүр бөгөөд бараа ч гэж үйлчилгээ ч гэж үзэж болохгүй харин наад захын хүний эрх болохыг давтан хэлмээр байна.

76. Байгаль цаг уур, тогтоцын хүндрэлтэй байдал, эдийн засгийн бэрхшээл зэргээс үл хамааран сургуулийн тийм дэлгэрэнгүй тогтолцоо сүлжээг бий болгож, ажиллуулж чадсан ард түмний их итгэл зүтгэлийг тод цохон тэмдэглэж байна. Том нутагтай, цөөн хүн амтай улсын хувьд бага, дунд сургуулийн элсэлт тийм өндөр байгаа нь тэмдэглүүштэй зүйл бөгөөд үүнд Засгийн газар ийм амжилт гаргасанд нь сайшаавал зохино.

77. Мөн цаашилбал бага ангийн бүх хүүхдийг үдийн цайгаар үнэгүй хангаж байгаа, явуулын гэр цэцэрлэг хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн, мөн бусад өмнө дурдсан жишээнүүдийг оруулаад Засгийн газрын авч хэрэгжүүлж байгаа сүүлийн үеийн санаачилгаас бусад улсууд үлгэр жишээ авч болох бөгөөд боловсролын төлөө гаргах хүчин чармайлтдаа харуулж чадсан Монголын ард түмний шинэлэг санаачилгыг тусгаж болох юм. Энэ санаачилга нь хүмүүсийн боловсролд өгч байгаа үнэ цэнэ, ач холбогдолд тусгалаа олж байгаа бөгөөд хамгийн алслагдмал орших гэрт ч гэсэн малчин айл хүүхдээ дээд боловсрол эзэмшүүлэх гэсэн хүслээ тусгай илтгэгчид хэлж байсан юм.

78. Гэсэн хэдий ч хүүхдүүдийн бага дунд сургуулиас завсардаж байгаа хувь хэмжээ, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол олох хязгаарлагдмал боломж, эдгээр болон бусад үзэгдлийн тухайд баталгаатай тоо баримт байхгүй байгаа зэрэг нь тусгай илтгэгчийн санааг зовоож байна. Мөн тусгай илтгэгч сургуулийн барилга, дотуур байр нь хуучирч муудсан, зарим тохиолдолд шаардлага хангахгүй байгааг тэмдэглэсэн. Хөдөө орон нутагт тааруухан нөхцөл байдал дээр усны болон, эрүүл ахуйн асуудал нэрмэж байхад хөдөөнөөс хот руу чиглэсэн нүүдлээс болоод хотын сургуулиуд ачаалал нь хэтрэх

<sup>74</sup> A/64/273, para. 63

хүндрэлд ороод байна. Хүний эрхийн соёл төлөвшөөгүй байдал эмэгтэйчүүдийн идэвх оролцоо төрийн албанд, ялангуяа шийдвэр гаргах түвшинд дутмаг байгаагаас харагдаж байна.

79. Дээр дурдсанаас үндэслэн Тусгай илтгэгч Монгол Улсын Засгийн газар болон Монгол Улс дахь олон улсын байгууллагуудыг дараах арга хэмжээг авахыг зөвлөж байна. Үүнд:

- Боловсролд зохих хөрөнгө оруулалтыг хийж, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны Яамны төсөвт шаардлагатай санхүүжилтүүдийг (доод тал нь ДНБ–ний 6 хувь буюу Улсын төсвийн 20 хувьтай тэнцэх) хуваарилан зарцуулах, Эдийн засаг, санхүүгийн хямралтай нөхцөлд ч гэсэн тогтвортой, хангалттай санхүүжилт хийх хэрэгтэй байгааг анхаарах;
- Сургуулийн дэд бүтцийн асуудлыг, ялангуяа хөдөө нутгуудад, анхаарах, ус урсдаг ариун цэврийн байгууламж бүхий, шаардлага хангахуйц халаалттайгаар сургуулиудыг шинэчлэх хөтөлбөр боловсруулах;
- Эрүүл мэнд ариун цэврийн талаар сургуульд сурсан мэдлэг нийт нийгмийн хэмжээнд эрүүл ахуйн нөхцөл байдал сайжрахад түлхэц болдог тул энэ тухай амьдралд хэрэгтэй мэдлэг чадварыг заан сургах тал дээр гарч байгаа санаачилгыг дэмжих;
- Сургуулиудын ачаалал хэтэрсэн хот болон хотжисон газруудад шинээр суурьшсан хүн амын хэрэгцээ шаардлагад нийцүүлэхээр тэргүүлэх зорилтын нэг болгож сургуулиудын барилгыг өргөтгөх;
- Статистикийн тоо баримтыг, ялангуяа, сургуульд элсэж байгаа болон сургуулиас завсардаж байгаа тал дээр чанаржуулах, “сургууль завсардал” болон түүний үр дагавар гэдгийг зөв томъёолж тодорхойлохын тулд илүү нарийн судалгаа хийх шаардлагатай.
- Ирц бүртгэл хөтлөх талаар ялангуяа хөдөөгийн сургуулиудад зориулж илүү боловсронгуй бодлого журам гаргах, багш нар, нийгмийн ажилтнуудад ирц, болон бусад холбогдох мэдээллийг хэрхэн зөв хөтлөх талаар сургалт явуулах шаардлагатай.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бүртгэл мэдээлэл, тоо баримтыг илүү нарийн нягт хийж тэдний бэрхшээлийг тодорхойлон, сургуульд бие организмын хувьд дэмжлэг өгөх болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн зорчих хэрэгсэл боломж хэрэгсэл, тэдэнд хичээл заах багш нарыг бэлтгэх зэрэг боловсролын хэрэгцээнд нь нийцсэн арга хэмжээ авах;
- Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг энгийн сургалтын тогтолцоонд шат дараатайгаар шилжүүлж болохоор сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх, Монгол Улс нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг соёрхон баталсан бөгөөд энэ талаар үүрэг хүлээсэн улс мөн.
- Нүүдлийн гэр цэцэрлэгийн санаачилгыг улам бүр дэлгэрүүлэх. Тусгай илтгэгч энэ бүтээлч хөтөлбөр нь Монголын нүүдэлчин, хөдөөгийн хүн амын бодит байдалд сайтар тохирсон, балчир насны хүүхдийн хөгжил, гэр бүл дотор сургуулийн бэлтгэл хангахад тун хэрэгтэй ажил гэж үзэж байна.

- Багш нарыг сургах, бүх салбарт шийдвэр гаргах албан тушаалд өрсөлдөхөд, цаашилбал улс орны төрийн болон улс төрийн амьдралд оролцоход нь эмэгтэйчүүдийг дэмжих зэргээр бүх түвшинд алсын хараатай жендэрийн төлөвийг бий болгох;
- Монгол үндэстэн болон бусад үндэсний цөөнх найрсагаар зэрэгцэн оршиж байгааг бэхжүүлэхийн тулд Монгол Улс дахь бүх боловсролын төвүүдэд олон соёл хэлний санаачилгыг хөгжүүлэх.
- Хүний эрхийн зохиол бүтээлийг хэвлэн нийтлэх болон тэдгээрийг боловсролын байгууллагуудад түгээх ажлыг хөхиүлэн дэмжих. Энэ санаачилгыг олон улсын хамтын нийгэмлэг болон хүний эрхийн зохиол бүтээлийг монгол хэл рүү орчуулах ажилд оролцвол зохих Нэгдсэн Үндэстний Байгууллагын харьяа байгууллагууд дэмжиж, туслалцаа үзүүлэх нь зүйтэй.

80. Эцэст нь Тусгай илтгэгч Дэлхийн Банкинд ... үргэлжлүүлэхийг зөвлөж байна. 2006 оны 9 дүгээр сард Монгол Улсыг Fast Track Initiative–д хамруулж эхэлсэн цагаас хойш тус улс нийт 29.4 сая ам долларын тэтгэлгийг тус санаачилгын Catalytic Fund–аас Монгол Улс дахь анхан шатны боловсролын хүртээмж, чанарыг сайжруулахаар хүлээн авсан байна. Санхүүгийн хямралын нөлөөг харгалзан энэ хөтөлбөрийн үргэлжлэх хугацааг наад тал нь эдийн засгийн сэргэлт ажиглагдтал сунгах нь зүйтэй.



**10.4 НҮБ–ЫН НЭН ЯДУУРАЛ БОЛОН  
ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН ТУСГАЙ ИЛТГЭГЧ  
МАГДАЛЕНА СЕПУЛВЕДА КАРМОНАГИЙН ТАЙЛАН**

**Нэмэлт**

2013 оны 12 дугаар сарын 3–наас 7–ны өдрүүдэд Монгол Улсад ажиллав.

***Хураангуй***

НҮБ–ын Нэн ядуурал болон хүний эрхийн асуудлаарх Тусгай илтгэгч 2012 оны 12 дугаар сарын 3–7 өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийсэн. Тус улсад хийсэн айлчлалынхаа явцад Тусгай илтгэгч нэн ядуу нөхцөлд амьдарч буй хүмүүсийн нөхцөл байдалтай өөрийн биеээр танилцаж, ядуурлыг бууруулах, улс орноо хөгжүүлэх зорилгоор төрөөс хэрэгжүүлж буй бодлогын бодит үр нөлөөний талаарх мэдээллийг цуглуулсан.

Энэхүү тайланд Тусгай илтгэгчийн ядуурлыг бууруулах, ядуу нөхцөлд амьдарч буй иргэдийн эрхийг хангах тал дээр Монгол Улсад тулгарч буй гол бэрхшээл сорилуудын талаар тоймлон тайлбарласан. Тусгай илтгэгч нэн ядууралд байгаа хүн амын эмзэг хэсэгт тулгарч буй хүндрэл бэрхшээлүүдийг ангилан тодорхойлохын зэрэгцээ тэдгээр иргэд олгогдсон эрхээ эдлэж чадахгүй байгаа гол хүчин зүйлүүдийг онцолсон бөгөөд үүн дотор нийгмийн хамгаалалд хамрагдах, зохистой орон сууцаар хангагдах болон шүүхээр эрхээ хамгаалуулах эрхийг онцгойлон хөндөв. Монгол Улсад эдийн засаг сүүлийн жилүүдэд эрчимтэй өсөж байгаа ч энэхүү өсөлт нь хүртээмжтэй бус байгаад сэтгэл зовниж буйгаа Тусгай илтгэгч тайландаа илэрхийлсэн бөгөөд эдийн засгийн амжилттай байгаа ч тэгш бус байдал хэт их байгааг тэмдэглэв. Тайлангийн төгсгөлд ядуурлыг бууруулах чиглэлээр шинээр байгуулагдсан Засгийн газрын зүгээс хэрэгжүүлж эхэлсэн зарим арга хэмжээний талаар өгүүлээд төрөл бүрийн оролцогч талуудад зориулсан зөвлөмжүүдийг тусгав.

**Хавсралт**

**НҮБ–ЫН НЭН ЯДУУРАЛ БОЛОН ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН  
ТУСГАЙ ИЛТГЭГЧ ХАТАГТАЙ МАГДАЛЕНА СЕПУЛВЕДА КАРМОНАГИЙН  
МОНГОЛ УЛСАД ХИЙСЭН АЖЛЫН АЙЛЧЛАЛЫН ТАЙЛАН  
/2012 оны 12 сарын 3–7/**

**I. Оршил**

1. Монгол Улсын Засгийн газрын урилгаар НҮБ–ын Нэн ядуурал болон хүний эрхийн асуудлаархи Тусгай илтгэгч Магдалена Сепулведа Кармона тус улсад 2012 оны 12 дугаар сарын 3–7 өдрүүдэд ажиллалаа. Хараат бус шинжээч болох Тусгай илтгэгч Сепулведа Кармона айлчлалынхаа үеэр нэн ядуу нөхцөлд амьдарч буй хүмүүсийн нөхцөл

байдалтай танилцаж, нийгэм эдийн засгийн хөгжил, нийгмийн хамгаалал, ядуурлын чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй бодлогын үр нөлөөний талаарх дүн шинжилгээг шууд эх сурвалжид суурилан хүний эрхийн өнцгөөс хийсэн болно.

2. Монгол Улсад ажиллах хугацаандаа Тусгай илтгэгч Гадаад харилцааны яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Хөдөлмөрийн яам зэрэг төрийн захигааны төв байгууллагууд болон Нийгмийн хамгаалал, үйлчилгээний ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Хүүхдийн төлөө үндэсний газар, Нөхөн сэргээх үндэсний төв, Жендэрийн үндэсний хороо зэрэг байгууллагуудын төлөөлөлтэй уулзаж ярилцсан.

3. Тусгай илтгэгч айлчлалынхаа хугацаанд Үндэсний статистикийн хороо, Хүний эрхийн Үндэсний Комисс болон тус улсад үйл ажиллагаа явуулдаг олон улсын санхүүгийн болон бусад байгууллагууд, хандивлагчид, иргэний нийгмийн хэд хэдэн байгууллагуудын төлөөлөлтэй уулзсан төдийгүй Төв аймгийн Эрдэнэ сум, Улаанбаатар хотын Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн Дарь-Эх, Өнөр орчмын ядуу иргэдтэй биечлэн уулзсан.

4. Монголд ажиллах урилгыг Тусгай илтгэгчид хүргүүлж айлчлалын хугацаанд бүх талаар дэмжлэг туслалцаа үзүүлж, хамтран ажилласан Монгол Улсын Засгийн газарт гүн талархлаа илэрхийлж байна. Мөн түүнчлэн айлчлалын бэлтгэл ажлыг хангах, айлчлалын зорилгыг амжилттай хэрэгжүүлэхэд чухал дэмжлэг үзүүлсэн Монгол дахь НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, тэр дундаа Суурин зохицуулагчийн газрын ажиллагсдад гүн талархлаа илэрхийлье. Айлчлалын зорилгыг биелүүлэхэд чухал хувь нэмэр оруулж, цаг гарган уулзсан бүх хүмүүс, иргэний нийгмийн байгууллагуудад талархлаа илэрхийлж байгаагийн дотор нэн ядуурлын гачаал зовлон, хүртээмжтэй бус байдлын талаар хувийн туршлагаасаа хуваалцсан хүмүүст онцгойлон талархаж байгаагаа илэрхийлье.

5. Хүний эрхийн механизм хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг хангах үүднээс тайлангийн “ядуус ба хүний эрх” сэдэвт зориулсан хэсэгт Хүний эрх ба бизнесийн үйл ажиллагаа, үндэстэн дамнасан корпораци, бусад бизнесийн байгууллагуудын асуудлаархи Ажлын хэсгийн 2012 онд Монгол Улсад ажилласны дараа бэлтгэн гаргасан тайлангаас иш татсаныг мөн дурдах нь зүйтэй.

## II. Улс орны нөхцөл байдал

6. Сүүлийн жилүүдэд Монгол Улсын эдийн засаг хурдацтай өсч, 2011 оны байдлаар ДНБ-ний хэмжээ 8,558 тэрбум ам.доллар хүрч, доогуур дунд орлоготой орнуудын тоонд багтах болсон<sup>75</sup>. Ашигт малтмалын томоохон ордуудыг илрүүлсэн, уул уурхайн мега төслүүдэд гадаадын томоохон хөрөнгө оруулалт хийгдэж байгаа болон өмнийн Говьд нүүрсний томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулж байгаа зэргээс тус улсын эдийн засаг 2020 он гэхэд одоогийнхоос 3 дахин өснө гэсэн тооцоолол хийгдсэн байна.

7. Тус улсын эдийн засаг сүүлийн жилүүдэд гайхалтай өсч байгаагийн нэг илэрхийлэл нь 2000–2010 онуудад ДНБ жилд дунджаар 10.6 хувь өсч ирсэн явдал юм.

<sup>75</sup> Дэлхийн Банк, Монгол Улсын эдийн засгийн улирлын тойм, 2012

ДНБ–ний өсөлтийн хувь хэмжээ 2011 онд 17 хувь, 2012 оны 1–р улиралд 16,7 хувьд тус тус хүрсэн байна<sup>76</sup>. 2 Эдийн засаг ийнхүү хурдацтай өсч байгаа хэдий ч хүртээмжтэй байж чадахгүй байгаа бөгөөд нийгмийн хамгийн эмзэг хэсэгт эдийн засгийн ахиц дэвшил түн хүртээлгүй байж, ядуурлын төвшинг бууруулах тал дээр дорвитой ахиц гарсангүй. Монгол Улс 2013 оны Хүний хөгжлийн индексээр 186 орноос 108 байрт жагссан байна.

8. Статистикийн албан ёсны мэдээ мэдээллийн дагуу ядуурлын төвшин буурч байгаа бөгөөд 2010 онд тухайлбал 39,2 хувь байсан бол 2011 онд 29,8 хувь болж буурсан байна. Гэвч олдож буй баримт материалыг судалж үзэхэд тэгш бус байдал гүнзгийрсэн байдалтай байгаа бөгөөд хүн амын чинээлэг 10 хувийн хэрэглээ ядуу 10 хувийн хэрэглээнээс даруй 7.7 дахин их байна<sup>77</sup>.

9. Айлчлалынхаа үеэр Тусгай Илтгэгч ядуу нөхцөлд амьдарч буй иргэд орлогын тэгш бус байдалд ихээр өртөж байгаатай биеэр танилцаж, нийгэм дэх баян, ядуугийн ялгаа ихсэхийн хэрээр ядуурлын түвшин хөдөө орон нутаг төдийгүй хот суурин газарт нэмэгдэж байгааг тэмдэглэн авав. Орлогын энэхүү тэгш бус байдал нь хүний эрхийн асуудлуудыг зайлшгүй дагуулах бөгөөд байдлыг засч залруулахад чиглэсэн яаралтай арга хэмжээ авах шаардлагыг бий болгож байгаа юм.

10. Байгуулагдаад удаагүй байгаа Монгол Улсын Засгийн газарт ядуурлыг бууруулж улмаар үгүй болгох зорилгод нь үлэмж бэрхшээлүүд тулгарч байгааг Тусгай илтгэгчийн зүгээс сайтар ойлгож байна. Засгийн газар ажилласан богино хугацаандаа ядууралтай тэмцэх явдалд тэргүүлэх ач холбогдол өгч анхаарал хандуулан ажиллаж байгааг мөн сайшааж байна. Тийм ч учраас энэхүү тайланд тусгагдсан зөвлөмжүүдийг нааштай хүлээн авч ядууралд чиглэсэн төрийн бодлого нэн ялангуяа нийгмийн хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх бодлогыг хүний эрхийг дээдлэн хүндэлсэн, хамгаалан эдлүүлсэн, ядуусын асуудалд онцгойлон анхаарсан байлгана гэдэгт Тусгай Илтгэгч итгэж энэ тал дээр хүчин чармайлт гаргахыг Засгийн газраас хичээнгүйлэн хүсч байна.

### III. Хууль эрх зүйн болон институцын тогтолцоо

11. Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлэгт хүний эрх, эрх чөлөөний олон чанарт байдлыг тусгаж, иргэдийг эрхээ бүрэн дүүрэн эдлэхэд нь дэмжлэг үзүүлэх улс төрийн болон эрх зүйн орчинг бий болгосон. Үүний зэрэгцээ эмзэг бүлгийн амин чухал туслалцааны зэрэгцээ санхүүгийн болон эрх зүйн туслалцаа авах эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулж, “улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын амьдралын салбарууд болоод гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй” гэж заасан. Үндсэн хуульд хүний эрхийг хангаж, хамгаалахад төрийн хүлээх идэвхи санаачлагатай үүргийн талаар дэлгэрэнгүй заасан (19 дүгээр зүйл).

12. Монгол Улс хүний эрхийг хангаж, хамгаалах чиглэлд идэвхи чармайлт гаргаж ирснийг олон улсын хүний эрхийн гол гэрээ конвенциудын дийлэнхийг соёрхон баталж, дотоодын түвшинд тэдгээрийн хэрэгжилтийг сайжруулахад анхаарч, НҮБ–ын хүний

---

<sup>76</sup> Ibid.

<sup>77</sup> Монгол Улс, Статистикийн үндэсний хороо, 2012

эрхийн механизмд оролцож ирсэнээс харж болно. Монгол Улс хүчин төгөлдөр болоод удаагүй байгаа Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протоколыг соёрхон баталж, түүнд анхлан нэгдэн орсон улсуудын нэг нь болсон нь нэн сайшаалтай юм. Гэхдээ Монгол Улс олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлсэн эрх зүйн орчин дотооддоо бий болгож, хараахан нэгдэж ороогүй байгаа олон улсын гэрээнүүдийг соёрхон батлах зэргээр хүний эрхийг хүндэтгэн, хамгаалахад нэмэлт хүчин чармайлт тавьж ажиллах хэрэгтэй байна.

13. Үндсэн хуульд зааснаар төр “олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх” үүрэг хүлээх бөгөөд “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэдгийг мөн баталгаажуулж өгсөн.

14. Үндсэн хуульд хүнийг нийгмийн гарал үүсэл, эдийн засгийн байдлаар нь ялгаварлан гадуурхаж үл болно (14 дугаар зүйл) гэдгийг тодорхой зааж өгсөн. Гэсэн хэдий ч хүнийг бэлгийн чиг баримжаа, жендэр буюу эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхахыг хориглох тухай хууль тогтоомжид зааж өгөөгүй байгаад Тусгай Илтгэгч санаа зовниж байна. Үүний зэрэгцээ ялгаварлан гадуурхах аливаа хэлбэрт өртсөн хохирогчдод нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх үр нөлөөтэй механизм байхгүй нь анхаарах ёстой асуудал болж байна.

15. Монгол Улсын Их Хурлаас Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг 2003 онд баталсан явдал Монгол Улс хүний эрхийг дээдлэн хүндэтгэх тал дээр баттай зогсож байгааг дахин нотолсон. 2011 онд Засгийн газрын зүгээс уг хөтөлбөрийн хэрэгжилтэд цогц үнэлгээг хийсэн бөгөөд хүний эрхийн тухай олон улсын гэрээ конвенциудыг хэрэгжүүлэх тал дээр алдаа дутагдал байгааг болон ажлын байран дахь хүний эрхэд хамаарах хэм хэмжээг зүй зохистойгоор хангуулахад шаардагдах хүчин чадал дутмаг байгааг тогтоосон<sup>78</sup>.

#### IV. Нийтлэг бэрхшээлүүд

##### **А. Бодлого хэрэгжилтэд гарсан дутагдал, залгамж чанар алдагдсан байдал**

16. Монгол Улс ядууралтай тэмцэх, хүний эрхийг хангахад чиглэсэн хууль, эрх зүйн сайн орчинг бий болгосон нь сайшаалтай хэрэг боловч гэр бүлийн хүчирхийлэл, хүн худалдаалах гээд нийгмийн олон бодлогын асуудлууд амьдралд хэрэгжихгүй байгаа талаарх мэдээлэл Тусгай Илтгэгч хүлээн авсан болно.

17. Сүүлийн хорин жилийн хугацаанд бодлого боловсруулах түвшинд залгамж чанар ихээхэн алдагдсан нь олон жишээ дээр харагдаж байна. Тухайлбал, Засгийн газар шинээр байгуулагдахад өмнөх Засгийн газрынхаа баталсан хууль тогтоомж, дэвшүүлсэн нийгмийн бодлогыг хүчингүй болгох буюу хэрэгжүүлэхгүй байх нь түгээмэл байна. Энэ тухайд иргэний нийгмийн байгууллагууд ихээхэн санаа зовнидог болохоо илэрхийлж байсны дотор сонгуулийн дараа бодлого боловсруулах үйл ажиллагааны бүтэц бүхэлдээ

<sup>78</sup> НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Монгол Улсын хүний эрхийн үндэсний чадавхыг сайжруулах нь, Төслийн баримт бичиг

өөрчлөгддөг гэж дурдсан нь Тусгай Илтгэгчийн анхаарлыг татсан юм.

18. Мөн Тусгай Илтгэгч ядуурлыг бууруулах бодлогын хэрэгжилтэд томоохон алдаа дутагдал байгааг олж харсан. Ихэнх салбарт аливаа нэг бодлогыг хэрэгжүүлэхдээ үр нөлөөний үнэлгээ хийдэггүйн дээр урт хугацааны зорилт, уялдаа холбоо, залгамж чанарыг хадгалахгүй байх нь түгээмэл байна. Дээр нь санхүүгийн болон байгаль орчны тогтвортой байдлыг хангаж хэрэгжүүлэхгүй байна. Гэтэл нэн ядуурлыг арилгахад ядуу нөхцөлд амьдарч буй иргэдийн нөхцөл байдалд илүү онцгойлон хандсан урт хугацааны бодлого хэрэгжүүлэх чухал байдаг. Үүний тулд нийгмийн бодлого, улс төрийн үйл ажиллагааны бүхий л хүрээг хамарсан цогц, уялдаа холбоотой бүтцийг бий болгох шаардлагатай. Засгийн газрын байгууллагуудын түвшинд хөрөнгө нөөц тарамдсан, зохицуулалт дутмаг байгаа нь авсан арга хэмжээг үр дүнгүй болгох, цаашлаад ядуу нөхцөлд амьдарч буй иргэдийн эрх зөрчигдөх нөхцлийг үүсгэж байна.

19. Монгол Улс дахь ядуурлын суурь шалтгааныг тодорхойлсон цогц судалгаа байхгүй, мөн ядуурлын нөхцөл байдлын талаар олон жилийг хамарсан тоо баримт дутмаг байна. Ядууралтай тэмцэх ажлыг хариуцаж, үйл ажиллагааг нь удирдан чиглүүлэх төрийн байгууллага байхгүйн дээр үүнд хэн ч хариуцлага хүлээхгүй байгаад Тусгай Илтгэгч харамсаж байна. Хэдийгээр ядуурлыг дорвитой бууруулахад ихээхэн хөрөнгө нөөц гаргаж байгаа ч дээр дурдсан шалтгаануудаас үүдэн зохих үр дүндээ хүрч чадахгүй байна.

20. Монгол Улсын Засгийн газрын зүгээс ядууралтай тэмцэх бодлого, үйл ажиллагаанд алдаа дутагдал гарсан, түүнийг засч залруулах шаардлагатай гэдгийг ойлгож байгааг Тусгай Илтгэгч төрийн байгууллагуудын төлөөлөлтэй уулзах явцдаа сонсож мэдсэн. Тиймээс цаашид олон салбарыг хамарсан бодлого хэрэгжүүлэх нь чухал бөгөөд ингэхдээ салбар хоорондын уялдаа холбоог хангасан, хариуцлага тооцох байнгын механизм бий болгох хэрэгтэй гэдгийг Тусгай Илтгэгч онцлон тэмдэглэж байна.

## **Б. Авлига, хээл хахууль**

21. 2011 оны Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгийн үеэр Монгол Улсад тэгш бус байдал хадгалагдах гол шалтгаан нь авлига, хээл хахууль гэдгийг тодорхойлж, үүнээс шалтгаалан нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж буурч байгааг онцолсон. Хэлэлцүүлгийн үеэр танилцуулсан авлигатай тэмцэх талаархи зөвлөмж (A/HRC/16/5-ийн 84.32 догол мөр)-ийг Монгол Улс хүлээн авч, хэрэгжүүлэх болсныг Тусгай Илтгэгч сайшааж байна. Монгол Улс нь Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр гаргах, Авлигатай тэмцэх үндэсний зөвлөл байгуулах, Авлигатай тэмцэх хууль батлан гаргах, НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийг соёрхон батлах, Авлигатай тэмцэх хараат бус байгууллага байгуулах, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль батлах зэрэг хүчин чармайлт гаргасан явдал нь авлига, хээл хахуультай тэмцэхэд чухал алхам боллоо гэж Тусгай Илтгэгч үзэж байна.

22. Монгол Улс хөгжил дэвшлийг бий болгож, ард иргэдийнхээ амьдрал ахуйг сайжруулахын тулд Мянганы Хөгжлийн ардчилсан засаглал, хүний эрхийн талаарх 9 дүгээр зорилтод хүрэх нь нэн чухал юм. Харин энэ зорилтыг хангахад авлига, хээл хахуулийн эсрэг тэмцэх явдал шийдвэрлэх үүрэгтэй гэж Монгол Улсын Засгийн газар

үзэж байна.

23. Монгол Улсын авлига, хээл хахуультай тэмцэх хүчин чармайлтад бодитой дэвшил гарахгүй байгаад Тусгай Илтгэгч санаа зовниж байна. Транспэрэнси Интернэшнл байгууллагын гаргадаг Авлигын индексээр Монгол Улс 2012 онд 174 орноос 94-р байранд жагссан<sup>79</sup>. Авлига хээл хахуулийг бууруулж, бүрэн хянаж байхад орон нутгийн удирдлагын хэт төвлөрөл, хурдацтай хотжилтоос үүдэн сайжруулах шаардлагатай орон нутгийн захиргааны хууль тогтоомж, сонирхлын зөрчил зэрэг нь ихээхэн саад төвөг учруулж байна<sup>80</sup>.

24. Монгол Улсын Засгийн газрын зүгээс авлига, хээл хахуультай тэмцэхэд нэлээд хүчин чармайлт гаргаж байгаа нь сайшаалтай. Гэхдээ Тусгай Илтгэгч авлига, хээл хахууль, төрийн үүргээ биелүүлэх чадавхийг бууруулж, ядуу нөхцөлд амьдарч байгаа иргэдэд тэгш бусаар нөлөөлдөг болохыг энд онцлон дурьдахыг хүсч байна. Сүүлийн үед төрийн өндөр албан тушаалтнууд холбогдсон авлигын хэргийг ил гарган тавьж, тэднийг хариуцлагатай байлгах чиглэлд ажиллаж буйгаас нь харахад төрийн авлигатай тэмцэх үйл ажиллагаанд итгэл найдвар тавьж болохоор байна. Монгол Улсад, ялангуяа уул уурхайн салбарт хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын томоохон төслүүдийн үр шимийг нийгмийн бүх хэсэгт хүртээмжтэй байлгахад авлигын эсрэг тэмцэх, үл тэвчих бодлого баримтлах, хариуцлагатай байх зэрэг бодлогууд чухлаар тавигдаж байна.

## **V. Ядууралд өндөр эрсдэлтэй эмзэг бүлгийн нөхцөл байдал**

25. Тусгай Илтгэгч нэн ядуурал, нийгмийн ялгаварлан гадуурхалд өртөх өндөр эрсдэлтэй эмзэг бүлгүүдийг тодорхойлж, тэдэнд ямар бэрхшээл, сорилт тулгарч байгаа талаар энд дурдсан болно.

### **A. Эмэгтэйчүүд**

26. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцид нэн түрүүнд нэгдэн орсон орон болохын хувьд Монгол Улс эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах хууль, эрх зүйн иж бүрэн тогтолцоог бий болгож, ялангуяа жендэрийн тэгш байдлыг хангах, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлэхэд ихээхэн анхаарч ирсэн. Гэхдээ эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, тэднийг ялгаварлан гадуурхахгүй байхад баталсан хууль тогтоомжоо хэрэгжүүлэх нь юу юунаас илүү чухал юм.

27. Монгол Улсад эмэгтэйчүүд нийгэм, эдийн засгийн амьдралд идэвхтэй оролцож байгаа боловч шийдвэр гаргах түвшинд ихээхэн бага төлөөлөлтэй байгаа нь тоо баримтаас харагдаж байна. Тухайлбал, Парламент дахь эмэгтэй гишүүд 1990 онд нийт гишүүдийн 25 хувийг эзэлж байсан бол 2008 онд 3 хувь болж огцом буурсан<sup>81</sup>. 2012 оны Парламентын сонгуулийн үр дүнд ахиц гарч, эмэгтэй гишүүд 14,5 хувь<sup>82</sup> болсон байна.

<sup>79</sup> <http://www.transparency.org/country#MNG>

<sup>80</sup> НҮБ-ын Хөгжлийн Тусламжийн Хүрээ (UNDAF) 2012–2016, Монгол Улс, 63-р хуудас

<sup>81</sup> НҮБ-ын Хүүхдийн сан, Монгол Улс дахь Хүүхэд, Эмэгтэйчүүдийн талаарх судалгаа, 2009

<sup>82</sup> Одоогоор Парламентын 76 гишүүний 11 нь эмэгтэй гишүүд байна.

Энэ нь мэдээж нааштай дэвшил боловч эмэгтэйчүүдийн оролцоог улс төрд, ялангуяа шийдвэр гаргах түвшинд нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг Тусгай Илтгэгч төрөөс хүсч байна. Монгол Улс Мянганы Хөгжлийн зорилтод багтсан Хүйсийн тэгш байдлын талаархи зорилтод хүрэхийн тулд Засгийн газарт ажилладаг эмэгтэй шийдвэр гаргагчдыг 30–аас доошгүй хувьд хүргэх шаардлагатай байна.

28. Өрх толгойлсон эмэгтэйчүүд 1998 онд хүн амын 10 хувийг эзэлж байсан бол 2008 онд 15 хувь болж нэмэгдсэн гэсэн тооцоо байна. Өрх толгойлсон эмэгтэйчүүд ядууралд илүү өртөмтгий байна<sup>83</sup>. Гэртээ хүүхдээ асарч харах нь ихэнхдээ үнэлэгддэггүй бөгөөд энэхүү шалтгаанаас болоод өрх толгойлсон эмэгтэйчүүд өөр ажил эрхлэх боломжгүй байдаг. Ялангуяа, хүүхдийн асаргаа, халамжийн үйлчилгээ дутмаг байдаг хөдөө орон нутаг, алслагдсан газарт өрх толгойлсон эмэгтэйчүүд хөдөлмөр эрхлэхгүй байх нь илүү түгээмэл байна.

29. Жендэрийн хүчирхийлэл өндөр хэвээр байгаагийн зэрэгцээ ажлын байрны бэлгийн дарамт, хүн худалдаалах зэрэг эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн шинэ хэлбэрүүд бий болж байна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011) баталж, түүнийг хэрэгжүүлэх стратеги хөтөлбөр боловсруулсан нь хууль эрх зүйн тогтолцооны баттай үндсийг бий болгоход чухал алхам болсоныг сайшааж байна. Харамсалтай нь гэр бүлийн харилцаа, нийгмийн амьдралд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагын талаарх хэвшмэл үзэл ойлголт (CEDAW/C/MNG/CO/7) өнөөг хүртэл амь бөхтэй оршсоор байгаад Тусгай Илтгэгч санаа зовниж байна.

30. Хууль сахиулах байгууллагын ажилтнууд болон бусад хүмүүсийн дунд гэр бүлийн хүчирхийллийг хүний хувийн асуудал гэж үзсээр байгаа гэсэн мэдээллийг Тусгай Илтгэгч авсан. Ийм төрлийн гэмт хэрэг шүүхээр шийдэгдэх нь цөөн төдийгүй хохирогчдод түр хугацаагаар амьдрах байр, тэдэнд зориулсан эмнэлэгийн болон нөхөн сэргээх үйлчилгээ, туслалцаа үзүүлэх механизм дутагдалтай байна. Одоо шинэчлэгдэхээр яригдаж буй Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль (2005)–д хүүхдийн хамгааллын талаар тодорхой заалт байхгүй байгаа нь санаа зовоож байна.

31. Сүүлийн жилүүдэд хүн худаалдах гэмт хэрэг гарах болсон нь шийдвэрлэх шаардлагатай нийгмийн асуудлуудын нэг болж байна. Голчлон ядуу өрхийн 18–25 насны эмэгтэйчүүд хүн худалдаалах гэмт хэргийн золиос болж байна<sup>84</sup>. Бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдаалахын эсрэг үндэсний хөтөлбөр (2005–2014), Эрүүгийн хуульд 2008 онд оруулсан хүн худалдаахлах зорилгоор хүн элсүүлэх, тээвэрлэхтэй холбоотой нэмэлт, өөрчлөлт, Цагдаагийн Ерөнхий газрын дэргэд байгуулсан хүн худалдаалахтай тэмцэх тусгай нэгж (2010), Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012) зэрэг нь энэ асуудалтай тэмцэхэд тодорхой арга хэмжээ авч эхэлсний илрэл хэмээн Тусгай Илтгэгч үзэж байна. Хууль тогтоомж баталж, эрх зүйн орчин бий болгож байгаа зөв зүйтэй боловч баталсан хуулиа мөрдөж, хэрэгжүүлэхгүйгээр Монгол Улсад хүн худалдаалах гэмт хэргийг арилгаж устгах боломжгүй юм.

## **Б. Хүүхэд**

<sup>83</sup> НҮБ–ын Хөгжлийн Хөтөлбөр, Монголын Хүний Хөгжлийн Илтгэл 2011: Эмзэг байдлаас тогтвортой байдал руу: Байгаль орчин ба хүний хгжил (2001), 19–р хуудас

<sup>84</sup> АНУ–ын Төрийн Департамент, Хүний худалдаах гэмт хэргийн тайлан 2012, 253–р хуудас

32. Хүүхдийн эрхийн тухай конвенцийг 1990 онд соёрхон баталснаас хойш Монгол Улс хүүхдийг хамгаалах хууль тогтоомжууд батлан гаргах, бодлогын бусад арга хэмжээ авах зэргээр энэ чиглэлд ихээхэн хүчин чармайлт тавьж иржээ. Гэвч хүүхдийн эрхийг хамгаалах үйл ажиллагаанд тогтвортой хөрөнгө оруулалт хийгээгүйн улмаас хүүхдийн эрхийн талаарх заалтууд амьдралд бүрэн хэрэгжихгүй байна. 2008 онд нийт хүүхдэд, залуучуудын 43 хувь нь ядуу өрхөд амьдарч байснаас үзэхэд хүүхдийн ядуурал Монголын хүүхэд, залуучуудын ирээдүйд тулгамдсан асуудал болох нь тодорхой байна<sup>85</sup>.

33. 1990 оноос хойш хүүхдийн эндэгдлийг амжилттай бууруулж, 2015 онд хүрэхээр үүрэг амлалт авсан Мянганы Хөгжлийн зорилтод тусгагдсан хүүхдийн эндэгдлийн зорилтоо хугацаанаас нь өмнө буюу 2006 онд биелүүлсэн<sup>86</sup>. Гэвч хүүхдийн эндэгдэл ерөнхийдөө буурсан боловч өнөөдөр зарим газарт өндөр байна. Тухайлбал, хөдөө орон нутагт эмнэлгийн үйлчилгээ, ундны ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмж хязгаарлагдмал байдгаас хүүхдийн эндэгдэл харьцангуй өндөр байна<sup>87</sup>. Ихэнх тохиолдолд хоол тэжээлийн дутагдал хүүхдийн эндэгдлийн гол шалтгаан болж байгаад анхаарах шаардлагатай байна<sup>88</sup>.

34. Монгол Улс үнэ төлбөргүй, заавал эзэмших ёстой боловсрол олгоход ихээхэн амжилт олсныг Тусгай Илтгэгч сайшааж байна. Статистикийн тоо баримтаас үзэхэд, 2011 онд сургуулийн насны нийт хүүхдийн 93.5 хувь нь суурь боловсролд хамрагдсан бол тэдний 95 хувь нь дунд боловсрол эзэмшиж байсан байна<sup>89</sup>. Гэвч амьдралын хүнд нөхцөлөөс болж ядуу гэр бүлд амьдарч буй хүүхдүүд суурь боловсрол эзэмшээд цааш нь үргэлжлүүлэн суралцаж чадахгүй, сургууль завсардаж байгаад Тусгай Илтгэгч санаа зовниж байна. Мөн хөдөө орон нутагт амьдарч байгаа хүүхдүүд сургууль ихээхэн завсардаж байгаа бөгөөд тэдний 19 хувь нь найман жилийн сургууль төгсөж чадалгүй сургууль завсарддаг тухай статистикийн мэдээ бий<sup>90</sup>. Ялангуяа, алслагдсан газарт амьдардаг малчин өрхийн хүүхдүүд эцэг, эхээ даган байнга нүүдэллэж байдагаас сургуульд үргэлжлүүлэн суралцах боломжгүй тул тэдний дунд сургууль завсардалт ихээхэн түгээмэл байдаг. Үүнтэй адилаар, гэр бүлд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гүйцэтгэх үүргийн талаарх соёлын хандлагаас үүдэн хөвгүүд охидоос илүү сургууль завсардаж байна. Нүүж очсон газарт нь сургуулийн хүрэлцээ хангалтгүй, иргэний бүртгэлд бүртгүүлэхэд ихээхэн бэрхшээл учирдаг зэргээс шалтгаалан хот руу шилжин ирсэн өрхийн хүүхдүүд сургууль завсардаж, боловсрол эзэмших эрхээ эдэлж чадахгүй байна<sup>91</sup>.

35. Хүүхдийг эрхээ эдлэхэд нь тэдний эсрэг үйлдэж буй хүчирхийлэл ноцтой хохирол учруулж байгаа тухай тайлан мэдээлэл Тусгай Илтгэгч хүлээж авсан. Авсан мэдээллээс үзэхэд 2010 онд 2–14 насны хүүхдүүдийн 46 хувь нь гэртээ бие махбодийн болон сэтгэл зүйн ямар нэгэн хүчирхийлэлд өртсөн байна<sup>92</sup>. Цэцэрлэгт хүмүүжиж байгаа болон бага

<sup>85</sup> Өрхийн нийгэм–эдийн судалгаа 2007/2008–нд үндэслэн гаргасан НҮБ–ын Хүүхдийн сангийн тооцоо

<sup>86</sup> Монгол Улс, Мянганы Хөгжлийн зорилтуудын хэрэгжилт, Үндэсний 3 дахь тайлан (2009), 50–р хуудас

<sup>87</sup> НҮБ–ын Хүүхдийн сан, Монгол Улс: Хөтөлбөрийн баримт бичиг 2012–2016, 3–р хуудас

<sup>88</sup> НҮБ–ын Хөгжлийн тусламжийн хүрээ 2012–2016, 57–р хуудас

<sup>89</sup> Мөн тэнд, 57–р хуудас

<sup>90</sup> Мөн тэнд, 56–р хуудас

<sup>91</sup> НҮБ–ын Хөгжлийн тусламжийн хүрээ 2012–2016, 57–р хуудас

<sup>92</sup> Монгол Улс, Үндэсний Статистикийн хороо, НҮБ–ын Хүүхдийн сан, Олон үзүүлэлттэй кластерын судалгаа



боловсрол эзэмшиж байгаа хүүхдүүдийн гуравны хоёр нь хүчирхийллийн ямар нэг хэлбэр (эдийн засаг, сэтгэл зүй, бие махбодийн буюу бэлгийн)–т өртжээ<sup>93</sup>.

36. Монгол Улсад ажиллах хугацаандаа Тусгай Илтгэгч гудамжинд амьдардаг, орон гэргүй буюу өнчин хүүхдийг асарч, тэдэнд нийгмийн үйлчилгээ үзүүлдэг улсын санхүүжилттэй төвийн<sup>94</sup> нөхцөл байдалтай танилцсан. Тус төв асрамж, хамгаалалдаа байгаа хүүхдүүдээ тэжээлэг хоол хүнсээр хангах, дулаан хувцаслах, боловсрол эзэмшүүлэх, чөлөөт цагаа өнгөрөөх боломж олгох зэргээр тэдэнд эрүүл, аюулгүй орчин бий болгоход ихээхэн хүчин чармайлт гаргаж буйг Тусгай Илтгэгч талархан хүлээн авч байна. Ер нь ийм төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд халамж асаргаа хүртэх боломжгүй болсон хүүхдүүдийн хувьд хамгийн сүүлд очих газар нь болдог. Гэтэл улсынхаас бусад ийм төрлийн үйл ажиллагаа явуулдаг төвүүдэд нэгдсэн стандарт мөрдөгддөггүй, нийтдээ маш олон хүүхдийг шаардлагагүйгээр, хэтэрхий удаан хугацаагаар байлгадаг болох нь харагдсан. Ийм төвүүдэд байлгах гэхээсээ илүү аль болох хүүхдийг гэр бүл, хамаатан садангийнх нь асран хамгаалалд байлгах нь хамгийн зөв арга тул гэр бүлийнх нь эд материалын гачигдлыг шийдвэрлэх юмуу эсвэл гэр бүлийн өөр орчинд байлгах замаар хүүхдийг гэр бүл, хамаатан садангийнхаа хамгаалалд үлдэх буюу эргэн очих бололцоог хангаж, тэдний эрх ашгийг хамгаалах нь чухал гэдгийг Тусгай Илтгэгч онцлон тэмдэглэж байна.

37. Өнөөдөр Монгол Улсад хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн 66 хувь нь тэвчишгүй хөдөлмөр эрхэлдэг. Үүнээс үзэхэд хүүхдийн хөдөлмөр тулгамдсан асуудал болсон нь тодорхой байна<sup>95</sup>. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах үндэсний үйл ажиллагааны хөтөлбөрийг 2012 оны 12 дугаар сард баталсныг талархан хүлээн авч, энэ асуудлаар Үндэсний хороог хойшлуулалгүйгээр байгуулах, хөтөлбөрийн бүрэн хэрэгжилтийг хангахыг Тусгай Илтгэгч Засгийн газраас хүсч байна.

38. Хурдан морь унаач хүүхдүүдийн дунд унаж бэртэх, амь насаа алдах явдал гарч байгаад Тусгай Илтгэгч санаа зовниж байна. Хүүхдээр хурдан морь унуулснаар тэдний мөлжлөгийн шинж чанартай, аюултай, хортой хөдөлмөр эрхлэхээс хамгаалуулах эрхийг нь ноцтой зөрчиж байна. Иймд Хүний эрхийн Үндэсний Комисс, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй НҮБ–ын төрөлжсөн байгууллагуудаас гаргасан зөвлөмжүүдэд нийцүүлэн тэднийг хамгаалах яаралтай арга хэмжээ авах шаардлагатай байна.

39. Монгол Улсын Засгийн газар 2002–2010 онд хэрэгжүүлэх Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийг Хүүхдийн төлөө үндэсний газартай хамтран 2002 онд батлан гаргасан. Харамсалтай нь хөрөнгө мөнгө, санхүүжилт байхгүйн улмаас энэ хөтөлбөрт орсон олон төсөл, төлөвлөгөө хэрэгжээгүй өнгөрсөн<sup>96</sup>. Мөн НҮБ–ын Хүүхдийн сан, олон улсын бусад байгууллагуудтай хамтран Хүүхэд хамгааллыг бэхжүүлэх стратегийг боловсруулсан боловч стратегийг батлах үйл явц удаан, энэ чиглэлд ахиц

---

2010, 76– р хуудас

<sup>93</sup> Монгол Улс, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам, НҮБ–ын Хүүхдийн сан, Сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн хөгжлийн нэгдсэн бодлогын хэрэгжилтийн тойм, 2007

<sup>94</sup> Хүүхдийн сургалт, боловсролын тусгай төв, Улаанбаатар хот, Монгол Улс

<sup>95</sup> АНУ–ын Төрийн Департамент, Монгол Улс дахь хүүхдийн хөдөлмөрийн тайлан(2009), 415–416 хуудас

<sup>96</sup> АНУ–ын Төрийн Департамент, Монгол Улс дахь хүүхдийн хөдөлмөрийн тайлан(2009), 112–р хуудас

дэвшил бага гарсан нь тайлангаас харагдаж байна<sup>97</sup>.

### **В. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд**

40. Монгол Улсад 100 мянга гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна<sup>98</sup> (Үндэсний статистикийн хорооны мэдээгээр<sup>99</sup> 2008 онд 79 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн албан ёсоор бүртгэгдсэн). 2010 оноос хойш Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай конвенц, түүний нэмэлт протоколд нэгдэн орж, 2008–2012 оны үйл ажиллагааны төлөвлөгөө зэрэг эрх зүйн баримт бичиг, үндэсний хөтөлбөрийг баталсан. Эдгээрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд стандарт хангасан нөхцөл, таатай орчин бий болгох зэрэг олон зорилтыг тусгасан.

41. Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах чиглэлд анхаарал хандуулан ажиллаж ирснийг Тусгай Илтгэгч талархан хүлээн авч байна. Гэвч хот суурин, хөдөө орон нутгийн хаана ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бусдын нэгэн адил нийтэд нээлттэй үйлчлэх буюу зориулагдсан объект, үйлчилгээг хүртэх хүртээмжийг бий болгоход чиглэсэн арга хэмжээ дутмаг байгаад санаа зовниж байна (Конвенцийн 9 дүгээр зүйл). Мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай конвенцийн 28 дугаар зүйлд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бие даан амьдрах, амьдралын бүхий л хүрээнд бүрэн дүүрэн оролцох боломжийг хангахын тулд төрөөс нэмэлт арга хэмжээ авч ажиллах хэрэгтэй байна.

42. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд боловсрол эзэмших, ялангуяа албан бус, богино хугацааны ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамрагдах, хөдөлмөр эрхлэх буюу орлого олох үйл ажиллагаа явуулах боломж хязгаарлагдмал байгаад Тусгай Илтгэгч санаа зовниж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсрол эзэмших эрхээ эдлэхэд ихээхэн бэрхшээл хүндрэл тулгарч байна. Тиймээс бүх түвшинд боловсролын системийг хүртээмжтэй байлгахад чиглэсэн арга хэмжээ авах шаардлагатай. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд хөгжлийн бэрхшээлийн улмаас үнэ төлбөргүй, заавал эзэмших ёстой суурь боловсрол олгох үйл ажиллагааны гадна үлдэх учиргүй юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол эзэмших эрхийг нь хангахын тулд төрөөс тэднийг боловсролын тогтолцоонд өөрсдийн үр дүнтэйгээр сурч боловсрох нөхцөл байдлыг хангуулах үүднээс шаардлагатай дэмжлэг тусалцаа авах бололцоог нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

### **Г. Малчид**

43. Монгол Улсад малчин өрхүүд ДНБ-ний 21 хувийг үйлдвэрлэж, ажиллах хүчний 38 хувийг бүрдүүлж байна<sup>100</sup>. Нүүдлийн мал маллагаа байгаль орчны нөхцлөөс хамааран олон хэлбэртэй байдаг. Тухайлбал, малчид говь цөлийн бүсэд дан ганц

<sup>97</sup> Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Монгол Улсын Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг, 2010

<sup>98</sup> НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Монгол дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эдийн засаг, нийгмийн илүү сайн интеграцийн төлөө: Өнөөгийн нөхцөл байдал ба хэтийн төлөв (2010), 1–р хуудас

<sup>99</sup> Мөн тэнд

<sup>100</sup> НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээ 2012–2016, 46–р хуудас

нүүдлийн байдлаар мал малладаг бол илүү үржил шимтэй ой, хээр талын бүсэд хагас нүүдлийн байдлаар малаа маллан амьдарч байна. 2010 оны зуднаар Монголын 9000 орчим малчин малаа бүрэн барж, хэдэн мянган өрх малынхаа ихэнх хэсгийг алдсанаас хөдөө, орон нутагт ядуурал эрс нэмэгдсэн. Нэн алслагдсан газарт амьдарч буй малчид нь эрүүл мэндийн халамж, боловсролын үйлчилгээ хүртэхэд ихээхэн бэрхшээлтэй байдаг. Түүнчлэн ажилгүйдэл өргөн тархсан, хот суурингийн төвөөс алслагдсан газарт амьдардаг малчдын хувьд дахин сургалтад хамрагдах, шинэ ур чадвар эзэмших боломж нь хязгаарлагдмал байдаг<sup>101</sup>.

44. Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хөдөөгийн малчин өрх байнга, алс хол нүүхэд хүрч байна. Энэ нь тэдний хүүхдүүдийг боловсрол эзэмшихэд нь ихээхэн сөргөөр нөлөөлж байна. Мөн бэлчээрийн доройтлын улмаас орон нутгийн эдийн засгийн чадавх буурч, үүнийг дагаад тэндээс орлого олж амьдардаг өрх толгойлсон эмэгтэйчүүдийн нөхцөл хүндэрч байна. Хөдөө орон нутагт амьдрах нөхцөл байхгүй болж байгаагаас малчид хот руу нүүхэд хүрч байна. Гэтэл шилжин ирсэн хүн ам төвлөрсөн газарт сургууль, эмнэлэг хүрэлцээгүй, ундны ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмж нэн дутмаг буюу огт байхгүй, тээврийн үйлчилгээ хүрээгүй байдаг. Ийм байдлаар нийгмийн суурь үйлчилгээ хүртэх бололцоо хязгаарлагдмал байдгаас шилжин суурьшигчид нэн хүнд нөхцөлд амьдарч байна. Цаашлаад бүртгэлгүй, эзэмшсэн ур чадваргүй байгаа нь тэдний байдлыг улам бүр хүндрүүлдэг.

45. Сүүлийн жилүүдэд уул уурхай эрчимтэй хөгжиж, малын бэлчээр, усны ойр орчимд олборлох үйл ажиллагаа явуулах болсон нь малчдыг бэлчээр хайн, алслагдмал газар руу нүүхэд хүргэж байна. Алслагдсан газарт нүүх нь малчдын эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн суурь үйлчилгээ хүртэх бололцоог нь хязгаарлаж байна. Төрөөс бүх сумдад эрүүл мэндийн халамж, боловсролын үйлчилгээг хангалттай хүртээмжтэй болгоход анхаарч, уул уурхайн үйл ажиллагаа явуулж эхлэхээс өмнө дэд бүтцийн зохих төлөвлөлт хийх шаардлагатай гэсэн. Хүний эрх ба бизнесийн үйл ажиллагаа, үндэстэн дамнасан корпораци, бусад бизнесийн байгууллагуудын асуудлаархи Ажлын хэсгийн 2012 онд Монгол Улсад ажилласны дараа бэлтгэн гаргасан зөвлөмжтэй Тусгай Илтгэгч санал нэгдэж байна.

46. Малчдын талаар баримтлах төрийн бодлого (2009) гарч, Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр (2010) батлагдсан нь сайшаалтай боловч ихэнх нь хэрэгжихгүй байгаа нь малчдыг байгаль орчны өөрчлөлт, түүнээс үүдсэн ядууралд улам бүр эмзэг болгож байгаад Тусгай Илтгэгч санаа зовниж байна. Тиймээс малчдын амьдрах нөхцлийг сайжруулах, малчид, ялангуяа залуу малчдыг шаардлагатай тохиолдолд өөр ажил эрхлэх чадвартай байлгах үүднээс тэднийг ур чадварт суурилсан сургалтад хамруулах механизм бий болгох бодлого боловсруулан, хэрэгжүүлэхийг Тусгай Илтгэгч Засгийн газраас хүсч байна.

---

<sup>101</sup> НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Монголын Хүний Хөгжлийн Илтгэл 2011: Эмзэг байдлаас тогтвортой байдал руу: Байгаль орчин ба хүний хөгжил (2001), 66-р хуудас

#### Д. Үндэстний цөөнх

47. Монгол Улс нь олон үндэстэн, ястны өлгий нутаг бөгөөд нийт хүн амын 17,6 хувийг<sup>102</sup> барга, буриад, чантуу, дөрвөд, казах, цаатан, тува зэрэг үндэстний цөөнх эзэлдэг. Ерөнхийдөө үндэстний цөөнх иргэний харъяалалаас үүдэн олгогдсон хуульд заасан эрхээ эдэлдэг боловч зарим нэг үндэстний цөөнхийн эдийн засаг, нийгмийн болон соёлын хөгжлийн төвшин бусдаас доогуур байна. Хэдийгээр энэ нь төрөөс зориуд явуулж буй бодлого биш боловч үндэстний цөөнх албан бусаар алагчлалд өртөж байна.

48. Хүний эрхийг хэрэгжүүлэх үндэстний хөтөлбөрийн хүрээнд Монгол Улс үндэстний цөөнхийн эх хэлээрээ сурч боловсрох эрхийг хангах зэргээр тэдний эрхийг хамгаалах арга хэмжээ авч байгааг Тусгай Илтгэгч сайшааж байна. Боловсролын эрхийн талаарх Тусгай Илтгэгч 2010 онд Монгол Улсад айлчлах үеэрээ тэмдэглэж байсанчлан төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд үндэстний цөөнхийн эрхийг хамгаалахад нэлээд ахиц дэвшил гарч байна. Гэвч одоогоор үндэстний цөөнхөд хандсан боловсролын бодлого байхгүй, боловсон хүчин дутмаг, үндэстний цөөнхийн хэлээр гарсан ном сурах бичиг хүрэлцээгүй байдгаас Монгол хэлээс өөр хэлтэй үндэстний цөөнх эх хэлээрээ боловсрол эзэмших эрхээ эдэлж чадахгүй байна. Тухайлбал, 2010 оны байдлаар Баян-Өлгий аймгийн казах хүүхдүүд хамгийн их сургууль завсардаж, сургуулийн өмнөх боловсролд хамгийн бага хамрагдсан байна. Харин тува хүүхдүүд аль ч шатны боловсролд тун бага хамрагддаг буюу огт хамрагддаггүй байна<sup>103</sup>.

49. Цөөнх хэлтний мэдээлэл авах бололцоог сайжруулах, ялангуяа Монголын олон нийтийн телевизийн хоёрдугаар сувгийг үндэстний буюу хэлний цөөнхийг мэдээллээр хангахад чиглүүлэн ажиллуулах, цөөнх хэлээр үйл ажиллагаа явуулах орон нутгийн мэдээллийн хэрэгсэл байгуулах зэргээр хүчин чармайлт тавьж буйг Тусгай Илтгэгч талархан хүлээн авч байна.

50. Дээр дурдсанчлан хүчин чармайлт тавьж ажиллаж байгаа ч үндэстний цөөнхүүд Монголын нийгмийн амьдралд өнөөг хэр нь бүрэн дүүрэн оролцож чадахгүй байна. Хүлээн авсан тайлангийн дагуу Цаа бугын аж ахуйг сэргээх, цаатнуудын амьдралын түвшинг сайжруулах хөтөлбөр зэрэг үндэстний цөөнхийг дэмжих олон төсөл, хөтөлбөр аймаг орон нутгийн төвшинд боловсруулагдсан хэдий ч төсвийн хүрэлцээ муу, яамдуудын хоорондын уялдаа холбоо байхгүйгээс үүдэн бүрэн хэрэгжиж чадахгүй байна<sup>104</sup>. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 169 дүгээр конвенцид Монгол Улс нэгдэн ороогүйн улмаас олон улсын хэм хэмжээгээр уугуул болон овог аймгийн тодорхойлолтод багтах үндэстний цөөнхийг тусгай эрхээр хангаж, хамгаалаагүй байна<sup>105</sup>.

51. Түүнчлэн, хууль эрх зүйн өнөөгийн орчин тодорхой үндэстний цөөнхүүдийг, ялангуяа казах үндэстнүүдийг харъяалалгүй болоход хүргэж буй талаарх мэдээлэл Тусгай Илтгэгч авсан. Энэ нь гол төлөв Монгол Улс хоёрдмол харъяаллыг зөвшөөрдөггүй,

<sup>102</sup> Монгол Улс, Үндэстний Статистикийн хороо, 2011

<sup>103</sup> НҮБ-ын Монгол Улс дахь баг, Монгол Улсын Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг (2010), 5-р хуудас

<sup>104</sup> Монгол Улсын Хүний эрхийн Үндэстний Комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний тайлан(2010), 90-91 хуудас

<sup>105</sup> Олон улсын цөөнхийн эрхийн бүлэг, Дэлхийн цнх, уугуул иргэдийн байдал 2011

гадаадын иргэн Монгол Улсын харьяалал авахын тулд эхлээд гадаад улсынхаа харьяаллаасаа татгалзах шаардлагатай байдагтай холбоотой. Монгол Улс, Казахстан улсын хооронд анхдагч харьяаллын талаар лавлагаа мэдээлэл солилцох үйл ажиллагаа удааширч байгаагийн улмаас олон казах үндэстэн Монгол Улсын харьяаллаа сэргээхийн тулд ихээхэн бэрхшээлтэй тулгардаг. Мөн харьяалалгүй иргэд харьяалалгүй гэж мэдэгдэхээсээ эмээж Монгол Улсын харьяатаа дахин сэргээх буюу харьяат болох хүсэлтээ холбогдох байгууллагуудад гаргадаггүй байна.

### **Е. Шилжин суурьшигчид**

52. Хүмүүс хот руу амьдралын нөхцлөө сайжруулах, хөдөлмөр эрхлэх, хүүхдийн боловсрол, эрүүл мэндийн халамж үйлчилгээ хүртэх зорилгоор нүүж байгаагаас хөдөө орон нутгаас хот суурин руу чиглэсэн шилжилт, хөдөлгөөн сүүлийн арван жилд эрс нэмэгдлээ. 2010 оны байдлаар нийт хүн амын 45 хувь нь дан ганц Улаанбаатар хотод амьдарч байв. Ихэнхдээ бүртгэлгүй явагддаг хүн амын шилжих хөдөлгөөн нь Засгийн газарт нийгэм-эдийн засгийн ихээхэн дарамт учруулдаг<sup>106</sup>.

53. Иргэний бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сантай болсон зэрэг дэвшил гарч байгаа ч хөдөө орон нутгаас шилжин ирэгсэд хаягийн бүртгэл хялбар, түргэн шуурхай хийлгэж чадахгүй, байнга бэрхшээлтэй тулгарч байна. Энэ нь тэдний газар өмчлөх, хөдөлмөр эрхлэх, хууль зүйн туслалцаа, хүүхдийн боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, төрийн бусад үйлчилгээ хүртэх боломжийг ноцтой хязгаарладаг. Мөн ажил хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай ур чадвар байхгүйгээс хот сууринд шилжин ирж, амьдарч байгаа өрхүүд хүүхдүүдээ тэжээлэг хоол хүнсээр хангах, дулаан хувцаслахад бэрхшээлтэйн байдгийн дээр дүрэмт хувцас, хичээлийн хэрэгсэл худалдан авах гээд наад захын хэрэгцээг нь хангах боломжгүй байдаг.

54. Мэдээ баримтаас үзэхэд, ядуу хүн хот суурин газарт ажил олох бололцоо бага, ажил эрхэлж буй эмэгтэйчүүд ижил ажлын байран дахь эрэгтэйчүүдээс бага цалин хөлс авдаг тэнд нийгмийн зөрчил, гэр бүлийн хүчирхийлэл нэмэгдэж байна<sup>107</sup>. Цаашлаад залуучуудын дунд ажилгүйдэл өндөр байгаа нь гэмт хэрэг, архидалт зэрэг нийгмийн асуудлуудыг даамжруулж болзошгүй.

55. Хөдөө орон нутгаас хот руу шилжин ирсэн хүмүүс хот суурин газрын тогтолцоо, үйлчилгээ авах арга замын талаар ойлголт мэдлэггүйн улмаас хотын амьдралтай дасан зохицоход ихээхэн бэрхшээлтэй тулгардаг болох нь Тусгай Илтгэгчийн анхаарлыг татлаа. Хөдөө орон нутгаас шилжин ирж, нийслэлд бүртгэлгүй амьдарч байгаа хүүхдүүдийн эрүүл мэндийн нөхцөлд тусгайлан анхаарал тавих хэрэгтэйг Тусгай Илтгэгч онцлон тэмдэглэж байна.

---

<sup>106</sup> Дэлхийн Эрүүл мэндийн Байгууллага, Монгол Улстай хамтран ажиллах стратеги, 2010– 2015, 14–р хуудас

<sup>107</sup> НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээ 2012–2016, 56–р хуудас

### **Ё. ХДХВ/ДОХ–той амьдарч буй хүмүүс**

56. Монгол Улс нь ХДХВ–ын тархалт багатай орнуудын нэг юм. 2011 оны эцсийн байдлаар 1992 оноос хойш халдвар авсан нийт 100 хүн бүртгэгдээд байна<sup>108</sup>. Өвчний тархалт бага байгаа боловч авсан мэдээллээс үзэхэд ХДХВ/ДОХ–той амьдарч буй хүмүүс ялгаварлан гадуурхалт, гутаан доромжлолд ихээхэн өртдөг. Ялгаварлан гадуурхалтын олон хэлбэр, ялангуяа эрүүл мэндийн үйлчилгээний байгууллагуудын зүгээс үзүүлэх ялгаварлан гадуурхалтаас үүдэн тэд өөрт ноогдсон эрүүл мэндийн үйлчилгээг авахаас татгалзахад хүрдэг. ХДХВ/ДОХ–той амьдарч буй хүмүүсийн өртөж буй ялгаварлан гадуурхалт, гутаан доромжлолыг багасгах зорилгоор ХДХВ/ДОХ–оос сэргийлэх тухай хуульд саяхан нэмэлт, өөрчлөлт оруулсныг Тусгай Илтгэгч сайшааж байна. Цаашид хуулийн заалтуудыг бүх түвшинд амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг механизм бий болгох нь зүйтэй гэж Тусгай Илтгэгч зөвлөж байна.

57. Монгол Улсад залууст учирч буй өнөөгийн эрсдэлд Тусгай Илтгэгч ихээхэн санаа зовниж байна. Хүн амын энэ хэсгийн дунд мэдээлэл, мэдлэг, ойлголт дутмаг, ажилгүйдэл, архидалт өндөр байгаа нь тэднийг бэлгийн замаар халдварладаг өвчин, ХДХВ/ДОХ–д онцгой эмзэг болгож байна.

58. ХДХВ/ДОХ–оос сэргийлэх ажлыг уялдуулан зохицуулах үндэсний хороог Засгийн газрын 240 дүгээр тогтоолоор 2006 онд байгуулсан. 2011 онд Засгийн газрын 7 дугаар тогтоолоор тус хорооны удирдлага, зохион байгуулалтыг Эрүүл мэндийн яаманд шилжүүлсэн. Уг хорооны ажлын үр дүнд зарим нэг ахиц дэвшил харагдаж байсан боловч шинэ Засгийн газрын тус хороог татан буулгахаар төлөвлөж буй нь харамсалтай байна.

59. Түүнчлэн, ХДХВ/ДОХ–той амьдарч буй хүмүүст үзүүлэх үйлчилгээг цаашид үргэлжлүүлэн хүргэх эсэх нь тодорхойгүй гэдэг тайланг Тусгай Илтгэгч хүлээн авсан. ХДХВ/ДОХ–той амьдарч буй хүмүүсийн эмчилгээ, халамж үйлчилгээ, тусламж дэмжлэгийг цогцоор хүртэх бололцоог хангахыг Тусгай Илтгэгч төрөөс хүсч байна.

### **Ж. Бэлгийн цөөнх**

60. Монгол Улсын Үндсэн хуульд ялгаварлан гадуурхахын эсрэг заалт байдаг боловч бэлгийн чиг баримжаан дээр үндэслэсэн ялгаварлан гадуурхахыг хориглох тухай хууль тогтоомжид тодорхой заагаагүй. Үүний улмаас Монгол Улсад лесбиян, гей, бисексуал, трансжендэр (ЛГБТ) хүмүүс бие махбодийн болон бэлгийн хүчирхийлэл амсах, шалтгаангүйгээр баривчлагдан саатуулагдах, баривчлагааны үеэр бие махбодийн болон бэлгийн хүчирхийлэл амсах зэргээр хүчирхийлэлд байнга өртөж байна (A/HRC/WG.6/9/MNG/3). Цагдаагийнхны цээрлэл, хавчлагад дахин өртөж, зовлон амсах вий гэсэн айдсын улмаас дарамт, хүчирхийлэлд өртсөнөө мэдэгдэхгүй байх нь элбэг байдаг.

61. ЛГБТ хүмүүсийн эсрэг байнга гардаг ялгаварлан гадуурхалт төрийн, хувийн, төрийн бус хүрээнд цагдаа, шүүх, эрүүл мэндийн байгууллага, боловсрол, орон байр, хэвлэл мэдээлэл гээд бараг бүх салбарыг хамардаг. Ийм хэлбэрийн доромжлол, гадуурхал нь ЛГБТ хүмүүсийг эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх, хөдөлмөр эрхлэх,

<sup>108</sup> Монгол Улсын Засгийн газар, ДОХ–той тэмцэх үйл ажиллагааны тайлан 2010 оны 1 сараас 2011 оны 12 сар (2012)

нийгэмд хүлээн зөвшөөрөгдөхөд нь томоохон тээг саад болдог. Гутаан доромжлолоос болоод боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэхэд хүндрэлтэй байдаг тул ЛГБТ хүмүүсийн нэлээд хэсэг нь ядуу нөхцөлд амьдарч буйд Тусгай Илтгэгч санаа зовниж байна.

62. ЛГБТ хүмүүсийн эрхийг үр нөлөөтэй хамгаалах үүднээс хууль тогтоомж боловсруулан гаргах, мэдээлэл түгээх, хүний эрхийн боловсрол олгох замаар нийгэм дэх ялгаварлан гадуурхах үзэл, ойлголтыг бууруулах, бэлгийн чиг баримжаанаас үүдэн үйлдэгдсэн хувь хүний эсрэг халдлага, хүчирхийллийг хууль, шүүхийн хүрээнд үнэн зөв, нарийн сайн мөрдөн шалгаж, шийтгэдэг байх нь зүйтэй гэсэн 2011 оны Монгол Улсын Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэхийг Тусгай Илтгэгч Засгийн газраас хүсч байна.

## **VI. Ядуу нөхцөлд амьдарч байгаа иргэд эрхээ эдлэхэд тулгарч буй сорилт бэрхшээл**

63. Ядуу нөхцөлд амьдарч буй хүмүүс бүх төрлийн эрхээ эдлэхтэй холбоотой сорилт бэрхшээлүүдтэй олон тулгардаг боловч тайлангийн энэ хэсэгт Тусгай Илтгэгчийн өмнөх тайлангууддаа нарийвчлан дурдсан болон энэ удаагийн айлчлалын үеэр дэлгэрэнгүй мэдээлэл авсан эрхүүдийн талаар дүгнэж авч үзнэ.

### **А. Нийгмийн хамгаалал хүртэх эрх**

64. НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын конвенц (9 дүгээр зүйл), Хүүхдийн эрхийн тухай конвенц (26 дугаар зүйл, 1 дэх заалт), Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцид заасанчлан нийгмийн хамгаалал хүртэх эрх нь олон улсын хүний эрхэд хамаарна. Конвенцийн дагуу нийгмийн хамгааллын эрхийг хэрэгжүүлэхийн тулд улс орнууд дотоодын хууль, эрх зүйн дагуу нийгмийн хамгаалал, туслалцаа үйлчилгээ үзүүлэх, тэдгээрийн тогтвортой байдлыг хангах, халамжийг хэмжээ болон хугацааны хувьд хүрэлцээтэй байх, халамжийн хэлбэр нь хүний нандин чанарыг хүндэтгэх, ялгаварлан гадуурхахгүй байх зарчимд нийцүүлсэн байх явдлыг хангаж ажиллана. Иймд улс орнууд нийгмийн хамгааллын тогтолцоог бий болгох үүрэг хүлээнэ.

65. 1990 онд ардчилсан хувьсгал өрнөснөөс хойш Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт богино хугацаанд шилжсэн. Үүнээс өмнө нийгмийн хамгааллын асуудалд төрийн оролцоо ихээхэн чухал нөлөөтэй байв. Харин шилжилтийн үетэй зэрэгцэн ядуурал нэмэгдэж, эдийн засгийн тодорхойгүй байдал бий болж, шийдвэрлэх шаардлагатай олон бэрхшээл сорилт тулгарсан. Урьд урьдын засгийн газрууд нийгмийн хамгааллын янз бүрийн хөтөлбөр хэрэгжүүлэх замаар ядуурал, тэгш бус байдлыг гэтлэн давахыг оролдож байлаа. Угаас хөрөнгө нөөц хязгаарлагдмал байдаг учраас өнөөгийн нөхцөлд тулгамдаж буй гол асуудал нь нийтийг хамарсан нийгмийн хамгааллын тогтолцоог өөрчлөн зорилтот бүлэгт чиглүүлэхэд оршиж байна.

66. 1995 онд нийгмийн хамгааллын шинэ тогтолцоо бий болсноос хойш энэхүү тогтолцооны гол бүрэлдэхүүн хэсгүүд болох нийгмийн халамжийн үйлчилгээ, тусламж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, нийгмийн даатгал зэрэг нь иргэдийг ядууралд

нэрвэгдэхээс түр аргацаах шинж чанартай байна<sup>109</sup>. Хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан зэрэг нийгмийн эмзэг бүлэгт чиглэсэн хэд хэдэн хөтөлбөр хэрэгжиж байгаа нь тэмдэглүүштэй.

67. Сүүлийн жилүүдэд багагүй ахиц дэвшил гарч байгаа боловч нийгмийн хөтөлбөрүүд зорьсон үр дүндээ хүрэх нь цөөн байна. Улс төрийн зорилготой, хэтэрхий тарамдсан, түр зуурын шинжтэй хөтөлбөрүүд нь Монголын хүн амын эмзэг хэсэгт хүрэхгүй, тэдний нийгмийн хамгаалал хүртэх эрхийг хөсөрдүүлж байна.

68. Түүнчлэн Тусгай Илтгэгчийн хүлээн авсан тайлангуудаас харахад сүүлийн жилүүдэд өмнөх Засгийн газрууд нийгмийн хамгааллын тогтолцоонд оруулах өөрчлөлтийг сонгуулийн санал авах хэрэгсэл болгон ашиглаж иржээ. Нийгмийн хамгааллын тогтолцоог улс төрийн зорилгоор өөрчлөх, ялангуяа бүх хүүхдэд тэтгэмж олгох хөтөлбөр нь хүн амын дунд төөрөгдөл үүсгэж, нийтийг хамарсан тогтолцоо үр нөлөөгүй гэсэн ерөнхий ойлголтыг төрүүлсэн. Нийтийг хамарсан тэтгэмж нь хүмүүсийн хөдөлмөр эрхлэх сэдэлд сөргөөр нөлөөлдөг, ядуу нөхцөлд амьдарч байгаа хүмүүс мөнгөө ухаалгаар зарцуулдаггүй гэсэн ямар нэг баттай нотолгоо байхгүй таамаглал нь өнөөдөр нийгмийн бодлогыг тодорхойлох үндэс болж байна. Өмнөх нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжүүлэхэд гарсан ноцтой алдаанууд нь нийтийг хамарсан халамжийн хөтөлбөрийн ашиг тусыг бүхэлд нь үгүйсгэх шалтгаан болох ёсгүй юм. Нийгмийн хамгааллын хөтөлбөрүүд нь нотолгоонд суурилсан, хүний эрхийн зарчим, хэм хэмжээ, ялангуяа ядуу нөхцөлд амьдарч буй хүмүүсийн бие даасан байх, үйл ажиллагаа явуулах эрхийг хүндэтгэсэн байх шаардлагатай.

69. Айлчлалын хугацаанд Тусгай Илтгэгч Засгийн газрын зүгээс нийгмийн хамгааллын шинэ стратеги боловсруулан хэрэгжүүлж байгаа тухай мэдээлэл авсан. Засгийн газрын зүгээс нийгмийн хамгааллын тогтолцоог улс төрөөс ангид байлган, сайжруулах болсныг талархан хүлээн авч байна.

70. Засгийн газрын зүгээс нийгмийн хамгааллын тогтолцоонд хүний эрхийн зарчмын үүднээс хандах хэрэгтэйг ойлгож, тодорхой арга хэмжээ авч буйг Тусгай Илтгэгч талархан дэмжиж байна. Энэ талаар болон тайлангийн хүрээнд, Засгийн газрыг олон улсын эрх зүй болон Үндсэн хуулийн хүрээнд авсан үүрэг амлалтдаа нийцүүлсэн, нийгмийн эмзэг хэсгийг нэн тэргүүнд тавьсан нийгмийн хамгааллын тогтолцоо бий болгоход нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Тусгай Илтгэгч зөвлөмж гаргасан болно<sup>110</sup>.

### **Зорилтот бүлгүүдийг тодорхойлох**

71. Зорилтот бүлгүүдийг хараат бус, нотолгоонд суурилсан тайлангууд дээр үндэслэн, нийт хүн ам, оролцогч бүх талуудтай зөвлөлдөх замаар шалгах аргачлалыг иж бүрнээр үнэлэн хэрэглэхийг Тусгай Илтгэгч Засгийн газраас хүсч байна. Энэхүү аргачлалыг хэрэгжүүлэхдээ захиргааны зардалд онцгой анхаарч ажиллах шаардлагатай.

<sup>109</sup> Азийн Хөгжлийн Банк (ADB), “Монгол Улсын Нийгмийн Хамгааллын салбарыг сайжруулах”, Нийгмийн хамгааллын төслийн товч тойм, 2009 оны 10 сар, 1–р хуудас

<sup>110</sup> Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос гаргасан Нийгмийн хамгааллын эрхийн талаарх 19 дугаар Ерөнхий зөвлөмж (2008)



72. Зорилтот бүлгүүдийг тодорхойлох механизм нь халамжийг хүн амын нэн ядуу хэсэгт хүргэх зорилготой боловч хүний эрхийн хувьд үүнийг анхаарч үзэх шаардлагатай. Хэдийгээр нийтийг хамарсан хамгааллыг алхам алхмаар бий болгох зорилготой урт хугацааны стратегийн хүрээнд хүн амын эмзэг, ядуу бүлгүүдийг нэн тэргүүнд сонгож авах байдлаар зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа ч энэ нь хүний тэгш эрхийн хэм хэмжээг тодорхой хэмжээгээр зөрчиж байгаа юм. Тиймээс зорилтот хөтөлбөрийг цаашид зөвхөн нийтийг хамарсан хамгаалал бий болгох төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлэх шаардлагатай байна.

73. Халамж хүртэгсдийг шударга бусаар ялган орхигдуулахгүй байх, хүний эрхийн бусад зарчмуудыг даган биелүүлэхийн тулд нийтийг хамарсан хамгааллыг алхам алхмаар бий болгох зорилготой урт хугацааны стратегийн хүрээнд зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь чухал.

74. Нийтийг хамарсан, оролцоонд суурилагүй халамж нь захиргааны зардал хамгийн бага шаарддаг, хамгийн энгийн тогтолцоо учраас зорьсон зорилтдоо хүрэх магадлал өндөртэй. Нийтийг хамарсан халамжийг бүх хүн авах бололцоотой учраас авлига үүсэх боломж бага бөгөөд халамж хүртсэнийхээ төлөө ямар нэг гутаан доромжлол хүлээдэггүй сайн талтай.

75. Орлогын тэгш бус байдал буюу ядууралыг арилгахад чиглэсэн тогтолцоог бий болгох нь нийгмийн зарим хэсгийг орхигдуулахад хүргэж болзошгүй. Учир нь халамж хүртэгсдийг сонгох ажиллагаа нь ярвигтай, бас ихэнхдээ маргаан дагуулдаг. Төрийн зүгээс энэ алдааг багасгахын тулд захиргааны зардлыг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлдэг зарим нэг механизм (Жишээ нь: зорилтот бүлгийг дахин шалгаж тодорхойлох, зорилтот бүлгийг дахин шинээр тогтоох)–ыг хэрэгжүүлдэг боловч халамжийг зүй ёсоор хүртэх шаардлагатай хүмүүсийг орхигдуулж, нийгмийн хамгаалал хүртэх эрхийг нь зөрчдөг. Халамжийн гадна үлдсэн хүмүүс нь ихэвчлэн халамжийн эрхээ шаардан хангуулах бололцоо багатай хүн амын эмзэг хэсэг байдаг.

76. Зорилтот бүлгүүдийг тодорхойлох нь Монгол Улсад хэрэгжүүлэхэд өртөг зардал хэт өндөр, төвөгтэй захиргааны тогтолцоо байж болох юм. Түүнчлэн төлөөлөх арга хэрэглэн шалгах аргачлал авч хэрэглэх нь тооцооллыг бүр ярвигтай болгож, улмаар шалгуур үзүүлэлтүүдийг ойлгомжгүй болгох, зорилтод халамж хүртэгсэд журмыг ойлгоход төвөг нөхцөл үүсгэж болох юм. Журам дүрэм, үйл явц ил тод бус байх нь хувь хүнийг хамгаалал хүртэх эрхээ хангуулахад ихээхэн бэрхшээл учруулдаг.

77. Өмнөх тайлангуудад онцлон тэмдэглэж байсанчлан дээр дурдсан шалтгааны улмаас нийтийг хамарсан хөтөлбөр нь дараах хүний эрхийн зарчимд нийцсэн байх шаардлагатай болохыг Тусгай Илтгэгч Засгийн газарт зөвлөн сануулж байна. Үүнд: (а) хүний эрхийн хэм хэмжээний түгээмэл зарчимд нийцэх, (б) тэгш байдал, үл ялгаварлан гадуурхах зарчимд нийцэх, (в) авлига, заль мэх гаргах нь голдуу нэн ядуу хэсгийн нийгмийн халамж хүртэх боломжийг нь хаадаг тул халамж хүртэгсдийг сонгож авахад эдгээрийн эрсдлийг бууруулах, (г) тавигдах шаардлагад нийцсэн хүмүүсийг халамж хүртсэнийхээ төлөө гутаан доромжлол амсах боломжийг бууруулах.

### **Хууль эрх зүйн болон институцын тогтолцоо, түүнд тулгуурлан гарсан урт хугацааны стратеги**

78. Нийгмийн хамгааллын тогтолцоог тогтвортой, ил тод, хариуцлагатай байлгахын тулд энэ талаар хууль тогтоомжинд<sup>111</sup> тусгаж өгөх шаардлагатай.

79. Хууль эрх зүйн болон институцын хүчтэй тогтолцоо үгүйлэгдэх, түүнд суурилсан урт хугацааны стратеги дутмаг байх нь нийгмийн хөтөлбөрүүдийг улс төрийн нөлөөлөлд эмзэг болгох сөрөг талтай. Мөн хөтөлбөрийн хэрэгжилтийн бүх шатанд төрийн байгууллагуудын оролцоог хууль эрх зүйн болон институцын хүрээнд хангаж урт хугацаагаар чадахгүй байх нь зорилтот хамгаалал хүртэгсдийг эрхээ эдлэхэд ноцтой саад учруулдаг.

80. Нийгмийн хамгааллын стратегийг санхүүгийн хувьд тогтвортой, найдвартай байж, үр нөлөөтэй хэрэгжихэд нь түүнийг хуулиар тодорхойлох, хэрэгжүүлэхэд нь хөрөнгө нөөц хуваарилах, бүтцийг нь урт хугацаагаар институц байгуулж баталгаажуулах явдал урьдач нөхцөл болно. Цаашлаад энэ нь нийгмийн хөтөлбөрүүд засгийн газар өөрчлөгдөх бүрт дуусгавар болох, орлогын буюу бусад дэмжлэг гэнэт зогссоны улмаас халамж хүртэгсдийг хөтөлбөр хэрэгжүүлж эхлэхээс өмнө байснаас илүү хүнд нөхцөлд оруулахгүй байхаас хамгаалах баталгаа болно.

### **Хүрэлцээтэй байх**

81. Төрийн зүгээс халамжийг хэмжээ болон хугацааны хувьд хүрэлцээтэй байх, халамжийн хэлбэр нь хүний нандин чанарыг хүндэтгэн, ялгаварлан гадуурхахгүй байхыг ханган ажиллах ёстой<sup>112</sup>.

### **Хариуцлагатай байх**

82. Хариуцлагын үр нөлөөтэй механизм нь халамж хүртэгсдийн хамгааллыг нэмэгдүүлээд зогсохгүй нийгмийн хөтөлбөрийн үр нөлөөг сайжруулж, алдаа дутагдал, буруу удирдлагын эрсдлийг бууруулж, нийгмийн хамгааллын тогтолцооны талаарх олон нийтийн дэмжлэгийг нэмэгдүүлдэг. Нийгмийн хамгааллын тогтолцоонд хариуцлага тооцох, түүнийг засч залруулах механизм байхгүй тохиолдолд ямар эрх, үүрэгтэй болох нь ойлгогдохгүй болох төдийгүй улс төрийн болон орон нутгийн элитүүдийн ашигладаг зорилгодоо ашигладаг ивээн хамгаалагч-үйлчлүүлэгчийн харилцааны хэрэгсэл мэтээр харагдахад хүргэнэ. Тиймээс нийгмийн хамгааллын хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагааг хянах хариуцлагын хараат бус, үр нөлөөтэй механизм болоод өргөдөл гомдол хүлээн авч, шийдвэрлэх механизм бий болгох нь эрх мэдэлтнүүд түүнийг буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэхэд нэн чухал юм.

### **Б. Орон сууц**

83. Монгол Улсын хөдөө орон нутаг, алслагдсан газарт ядуурлын түвшин өндөр боловч хот суурин газарт амьдралын нөхцөл илүү хүнд байна. 2000 оноос хойш Монгол

<sup>111</sup> Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос гаргасан Нийгмийн хамгааллын эрхийн талаарх 19 дугаар ерөнхий зөвлөмж (2008), 16-р догол мөр

<sup>112</sup> Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос гаргасан Нийгмийн хамгааллын эрхийн талаарх 19 дугаар ерөнхий зөвлөмж (2008), 22-р догол мөр

Улсад хотжилт хурдацтайгаар явагдаж байна. Улаанбаатар хотын хүн ам жилд 4,2 хувиар нэмэгддэг бол мөн хугацаанд хөдөө орон нутгийн хүн ам дунджаар 1,9 хувиар буурч байна. Нийслэл хотын хүн ам нийт хүн амын 44 хувийг, хот суурин газрын хүн ам 68 хувийг эзэлж байгаа нь Засгийн газарт нийгэм-эдийн засаг, эрүүл мэндийн томоохон сорилт бэрхшээл болж байна<sup>113</sup>. Хөдөө орон нутгийн хүн ам 2000 онд 43 хувь байсан бол 2010 онд буурч 32 хувь болов<sup>114</sup>.

84. Хот суурин газарт, ялангуяа Улаанбаатар хотод орон сууцны хэрэгцээ нь нийлүүлэлтээ давсан байгаа нь орон сууцны хангамж, нөхцөлд муугаар нөлөөлж байна. Тусгай Илтгэгчийн хүлээн авсан тайлангуудаас үзэхэд 2010 оны байдлаар Улаанбаатар хотын 273 мянган өрхийн 168 мянган өрх нь гэр хороололд амьдарч байна<sup>115</sup>. Тусгай Илтгэгч нийслэл хотын албан бус суурьшлын бүсэд амьдарч байгаа өрхүүдийн төлөөлөлтэй уулзаж, орон байр, ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмж хангалтгүй, нийгмийн суурь үйлчилгээ хүртэх нь хязгаарлагдмал, туйлын баталгаагүй нөхцөлд амьдарч буйтай биеэр танилцлаа. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын үзэж байгаагаар халаалтын систем хангалтгүй байгаагаас үүдсэн агаар, хөрсний бохирдол, амьсгалын замын өвчин, элэгний үрэвсэл зэрэг эрүүл мэндийн ноцтой эрсдэл үүсэх нөхцөл болж байна<sup>116</sup>.

85. Хүний эрхийн олон улсын эрх зүйн дагуу төр бүх орц материал нь шаардлага хангасан орон байраар хангах үүрэг хүлээдэг. Шаардлага хангасан орон сууцанд тавигдах шаардлагыг Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос гаргасан 4, 7 дугаар Ерөнхий зөвлөмжид тодорхойлж өгсөн. Энэхүү тавигдах шаардлагад хүртээмжтэй байх, үйлчилгээ авах боломжтой байх, оршин суух боломжтой байх, байршил, худалдан авахуйц байх гэсэн зарчмууд багтдаг. Хүртээмжтэй байх гэдэг нь найдвартай ундны ус, хоол унд бэлтгэх, халаах, гэрэлтүүлэх эрчим хүч, ариун цэвэр, угаалгын байгууламж, хоол хүнс хадгалах хэрэгсэл, хог хаягдал хаях газар, усны хоолойгоор хангагдах, яаралтай тусламж авах боломжтой байх зэргийг хэлнэ. Оршин суугчид орчны нөлөөлөл (Монголд хатуу өвөл болдгоос энэ нь нэн чухал), бусад эрүүл мэндэд учирч болох аюул, бүтцийн аюул занал, өвчний халдвар тээгчдээс хамгаалагдах шаардлагатай орон зайтай байх ёстой. Орон сууцны байршил нь хөдөлмөр эрхлэх сонголт олгох, эрүүл мэнд, халамжийн үйлчилгээ, сургууль, цэцэрлэг, бусад нийгмийн байгууламжийн хүртээмжтэй байх нөхцлийг хангаж байх шаардлагатай. Орон сууцны талаарх хууль тогтоомж, бодлогын аль аль нь хүн амын эмзэг бүлгүүдийн тусгай шаардлагыг бодолцож, түүнийг тусгасан байх ёстой<sup>117</sup>. Худалдан авахуйц байна гэдэг нь бас чухал. Орон сууцанд хувь хүний буюу гэр бүлийн төлөх төлбөрийн хэмжээ бусад суурь хэрэгцээгээ хангахтай нь тэнцэх буюу түүнээс өндөр байх ёсгүй. Энэ нь аргагүй нөхцөл байдлаас болоод өндөр үнэтэй орон сууц

<sup>113</sup> Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага, Монгол Улстай хамтран ажиллах стратеги, 2010– 2015, 16–р хуудас

<sup>114</sup> НҮБ-ын Хүн амын сан, Монгол Улсын нийгэм-эдийн засаг хөгжил, нийгмийн бодлогод үзүүлэх хүн амын чиг хандлагын нөлөө (2013)

<sup>115</sup> НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Монголын Хүний Хөгжлийн Илтгэл 2011: Эмзэг байдлаас тогтвортой байдал руу: Байгаль орчин ба хүний хөгжил (2001)

<sup>116</sup> Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага, Монгол Улстай хамтран ажиллах стратеги, 2010– 2015, 16–р хуудас

<sup>117</sup> Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос гаргасан Нийгмийн хамгааллын эрхийн талаарх 4 дүгээр ерөнхий зөвлөмж (1991)

сонгохоос өөр аргагүй болдог залуу гэр бүлүүдэд илүү хамааралтай. Тиймээс орон сууцны төлбөрийг нийт орлогын түвшинтэй шууд хамааралтай байлгах, орон сууц худалдан авах боломжгүй хэсэгт улсаас татаас олгож сууцаар хангах боломжийг судлах шаардлагатай.

86. Урьд өмнө байгаагүйгээр хурдацтай хотжиж буй хот суурин газрын хүн амыг шаардлагатай дэд бүтцээр хангахад Засгийн газарт ихээхэн бэрхшээл тулгарч байна гэж Тусгай Илтгэгч үзэж байна. Тэрээр өмнөх Засгийн газар, Улаанбаатар хотын захиргааг НҮБ-ын Хүн амын нутагшил, суурьшлын хөтөлбөр (НҮБ-ХАБИТАТ)-тэй хамтран гэр хорооллын нөхцлийг сайжруулах төсөл хэрэгжүүлж эхэлснийг талархан хүлээн авч байна. Гэвч хуучин орон сууцны барилгуудын шатны хөндийн хэсэгт амьдарч буй албан бус суурьшигчдын нөхцөл байдал санаа зовоосон асуудал болж байна. Тэдний амьдарч буй энэхүү баталгаагүй нөхцлийг хүний эрхийн зарчмын хүрээнд үнэлж, яаралтай шийдвэрлэх арга хэмжээ авах шаардлагатай байна.

### **В. Эрхээ хамгаалуулах эрх**

87. Сүүлийн жилүүдэд Засгийн газрыг зүгээс Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр (2007–2012)<sup>118</sup>, Шударга шүүхийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хүний эрхийг хамгаалах хамтарсан хөтөлбөр (2007) хэрэгжүүлэх зэргээр ядуу нөхцөлд амьдарч байгаа иргэдийн эрхээ хамгаалуулах явдлыг сайжруулах олон тооны санал санаачилга гаргасан. Эдгээр төслийн үр дүнд 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэг, 6 суманд хууль зүйн зөвлөлгөө өгөх төв байгуулагдлаа<sup>119</sup>. Хууль зүйн клиник, эвлэрүүлэн зуучлах зэрэг маргааныг шийдвэрлэх олон тооны механизм бий болсон боловч зарим тохиолдолд эдгээр төвүүдэд хязгаарлагдмал хөрөнгө нөөц хуваарилдаг нь үйлчилгээний чанарыг бууруулж байгаад Тусгай Илтгэгч санаа зовниж байна.

88. Хууль зүйн туслалцааны тухай хуулийн төсөл өнөөгийн эрх зүйн шинэчлэлийн нэг хэсэг болж батлагдах гэж байгаа гэсэн мэдээг Тусгай Илтгэгч хүлээн авсан. Засгийн газрын зүгээс хуулийн төслийг боловсруулах явцад өргөн хэмжээний хэлэлцүүлэг явуулсныг Тусгай Илтгэгч талархан хүлээн авч байгаа бөгөөд хуулийг цаг алдалгүй батлахыг дэмжиж уриалж байна. Мөн энэ нь цаашид хууль тогтоомжийг боловсруулахад олон нийтийн хэлэлцүүлэг хийх нэгэн жишиг болохыг Тусгай Илтгэгч зөвлөмж болгож байна.

89. Хүүхдийг шүүхтэй холбоотой тогтолцоонд чухал дэвшил гарч байгаа боловч хүний эрхийн олон улсын хэм хэмжээг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд хүчин чармайлт тавих шаардлагатай хэвээр байна. НҮБ-ын Хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн чиглэл (НҮБ-ын Ерөнхий Асамблейн 45/112 тогтоол)-д нийцүүлэн нөхөн сэргээх хөтөлбөр хэрэгжүүлэх, хүүхдийн гэмт хэргийн суурь шалтгаанд нь анхаарал хандуулах үүднээс хүүхэд төвт урьдчилан сэргийлэх арга барилыг нэвтрүүлэх, урьдчилан саатуулах байрыг зохих ёсоор, ялангуяа хүүхдэд ээлтэй байхаар тоноглоход анхаарахыг Тусгай Илтгэгч Засгийн газраас хүсч байна.

---

<sup>118</sup> НҮБ-ын Шударга шүүхийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хүний эрхийг хамгаалах төсөл, 2007 оны 4 сараас 2009 оны 6 сар

<sup>119</sup> НҮБ-ын Шударга шүүхийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хүний эрхийг хамгаалах төсөл

## VII. Олон улсын тусламж, хамтын ажиллагаа

90. Монгол Улс, дэлхийд хамгийн их гадаадын тусламжаас хамааралтай улс байсан бөгөөд 1991 оноос 2002 онд 2,5 тэрбум ам.долларын гадаадын тусламж авч байв. Гэвч сүүлийн жилүүдийн эдийн засгийн эрчимтэй өсөлтөөс үүдэн тусламжаас хамаарах хамаарал нь буурсан<sup>120</sup>.

91. Монгол Улс, доогуур дундаж орлоготой орон болсон боловч нийгмийн бодлогын хүрээг өргөжүүлэх, хүний эрхийн хууль эрх зүйн болон институцын тогтолцоог сайжруулах зэрэгт олон улсын хамтын ажиллагаа чухал хэвээр байна. Мөн нийгэмд тэгш бус байдал өндөр байгаа нь олон улсын хамтын нийгэмлэгийн дэмжлэгийг үргэлжлүүлэн авахыг шаардаж байгаа учраас ядуурлыг бууруулах цогц хөтөлбөр боловсруулахад шаардлагатай санхүүжилтээр туслахыг Тусгай Илтгэгч хандивлагч улс, байгууллагуудаас хүсч байна.

92. Түүнчлэн хандивлагч орон, олон улсын байгууллагуудын тусламжийн хүрээнд үзүүлж буй үйлчилгээг үргэлжлүүлэхэд анхаарал тавьж ажиллахыг Тусгай Илтгэгч Засгийн газраас хүсч байна. ХДХВ/ДОХ-той холбоотой тусламж, сүрьеэ өвчтэй амьдарч буй хүмүүст үзүүлж буй эрүүл мэндийн үйлчилгээнд онцгой анхаарал тавих нь зүйтэй. ХДХВ/ДОХ-той тэмцэх үйл ажиллагаа (Глобал сан), сүрьеэ өвчтэй хүмүүст үзүүлэх үйлчилгээ (GAVI нийгэмлэг)-ний санхүүжилт зогссон нөхцөлд энэ хоёр бүлэгт чиглэсэн үйлчилгээг үргэлжлүүлэх арга хэмжээ авахыг Тусгай Илтгэгч Засгийн газраас хүсч байна.

## VIII. Дүгнэлт, зөвлөмж

93. Засгийн газрын зүгээс ядуурал, тэгш бус байдалтай тэмцэх, орлогыг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах арга хэмжээний үр дүнг сайжруулахаар ажиллаж эхэлснийг Тусгай Илтгэгч сайшааж байна. Гэвч илтгэлд дурьдсанчлан, баян, ядуугийн хооронд орлогын ялгаа нэмэгдэх, ядуурлыг бууруулах талаархи хууль тогтоомж, бодлогод цоорхой үүсэх, авлигын байнгын эрсдэл зэрэг нь ихээхэн бэрхшээл учруулж байна. Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн үр шимийг хүн бүр хүртэж байх ирээдүйг цогцлооход ядуурлыг бууруулах стратегийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх нь чухал бөгөөд энэ талаар төрөөс яаралтай арга хэмжээ авах шаардлагатай байна.

94. Тайлангийн хэсэг бүрт зөвлөмжүүд орсон боловч Монгол Улсыг хүн амын ядуу хэсгийг эрхээ эдлэхийг нь сайжруулахад дараах алхамуудыг хийхийг хүсч байна.

95. Ядуурлыг бууруулах стратеги, түүний хэрэгжилтийн тухайд:

- а. Хүний эрхийн хэмжээнд суурилсан ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг аймаг, сумын хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан байхаар боловсруулах; Хэрэгжилтийг хангах цаг хугацааны нарийвчлалтай хэмжих үзүүлэлтийг тогтоож, хянах үр нөлөөтэй механизм бий болгох шаардлагатай.
- б. Ядуурлыг бууруулах үндэс суурийг бодитой бий болгохын тулд одоо мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг нь хангах, амжилттай хэрэгжиж буй бодлогыг үргэлжлүүлэх механизм бий болгох;

---

<sup>120</sup> Bertelsmann Stiftung Transformation Index (BTI)2012, Монгол Улсын тайлан

- в. Ядуурлыг бууруулах бодлого тодорхойлох үүрэгтэй яам, байгууллагыг томилж, хяналт, хариуцлагын механизм бий болгох;
  - г. Ядуурлын талаар тоо баримт цуглуулах ажлыг эрчимжүүлж, гарсан дүгнэлт судалгааг нийгмийн бодлого боловсруулан хэрэгжүүлэх, хөрөнгө нөөц хуваарилахад ашиглаж байх; Нийгмийн бодлого боловсруулан хэрэгжүүлэх, хөрөнгө нөөц хуваарилахад хүн амын ядуу хэсгийг нэн тэргүүнд анхаарч байх;
  - д. Авлигатай тэмцэх хууль тогтоомжийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх, авлигатай тэмцэх асуудлыг төрийн бүх байгууллагын хариуцлагын соёл болгохын үүднээс Авлигатай тэмцэх газар, Прокурорын ажил үүргийн хуваарийг тодорхой болгох;
96. Хууль эрх зүйн болон институцын тогтолцооны тухайд:
- е. Цаашид ядууралтай тэмцэх иж бүрэн тогтолцоо бий болгохын тулд одоо мөрдөгдөж буй хууль тогтоомж, бодлогын цоорхойг илрүүлэх тусгай ажлын хэсэг байгуулах;
  - ё. Хяналт, хариуцлагын механизмыг бэхжүүлэх замаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, шинэчлэн өөрчлөх гэж буй хууль тогтоомж (гэр бүлийн хууль, хүүхэд хамгааллын хууль, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль г.м)–ийг олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэх;
  - ж. Үндсэн хуульд орсон ялгаварлан гадуурхах тухай заалтыг бэлгийн чиг баримжаа, хүйс, эрүүл мэндийн байдал зэргээр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийн тухай олон улсын хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөх, эрх нь зөрчигдсөн тохиолдолд шүүхээр эрхээ хамгаалуулах, нөхөн сэргээх үйлчилгээ авах бололцоогоор хангах үр нөлөөтэй механизм бий болгох;
3. НҮБ–ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн III Нэмэлт Протоколыг хойшлуулалгүй соёрхон батлах;
- и. Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, эрхээ хамгаалуулах тухай конвенцид нэгдэн орох;
97. Ядууралд өртөмтгий нэн эмзэг бүлгүүдийн нөхцөл байдлын тухайд:

### **Эмэгтэйчүүд**

- а. Эмэгтэйчүүдийн оролцоог улс төр, ялангуяа шийдвэр гаргах төвшинд нэмэгдүүлэх, алслагдмал газарт амьдарч байгаа эмэгтэйчүүдийг улс төрийн амьдралд бүрэн дүүрэн оролцуулах
- б. Улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын амьдрал болон гэр бүлийн харилцаанд жендэрийн мэдрэмжтэй дадлыг бий болгохын тулд хүчин төгөлдөр үйлчилж буй жендэртэй холбоотой хууль тогтоомж, түүний дотор 2011 оны Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэх;
- в. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийг бүрэн хэрэгжүүлэх, хууль тогтоомжид тусгагдаагүй хүүхдийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх зорилгоор иргэний нийгмийн болон НҮБ–ын төрөлжсөн байгууллагуудтай хамтран ажиллах;

- г. Хууль сахиулах, шүүхийн байгууллагын ажилтнуудыг жендэрийн хүчирхийлэлтэй холбоотой сургалтад хамруулах, ийм хэрэг үйлдэгчдийг шүүхээр шийтгэх тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авах, хохирогчдыг түр хугацаагаар амьдрах байр, хуулийн болон сэтгэл зүйн зөвлөлгөө өгөх үйлчилгээгээр хангах;
- д. Жендэрийн тэгш байдлын үндэсний хороог эмэгтэйчүүдийн эрхийг хангах үүргээ биелүүлэхэд нь хүрэлцээтэй хөрөнгө нөөцөөр хангах;
- е. Ядууралд нэн эмзэг өрх толгойлсон болон ганц бие эмэгтэйчүүдийг хүрэлцээтэй хөрөнгө нөөцөөр хангах арга хэмжээ авах; Уг бодлого нь хөдөө орон нутаг, алслагдсан газарт амьдарч буй эмэгтэйчүүдэд онцгой анхаарал тавьсан, тэдний хөдөлмөр эрхлэх боломж, эрүүл мэндийн болон хүүхдийн асаргааны үйлчилгээ хүртэх асуудлыг хөндсөн байх;
- ё. 2012 оны 1 дүгээр сард баталсан Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлж, хүн худалдаалах гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл, охид, эмэгтэйчүүдийн бэлгийн хүчирхийллээс ангид байлгах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор хуулийн хэрэгжилтийг сайжруулах, эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох;
- ж. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын хамгаалах талаарх хуулинд тусгах, гэм буруутныг шүүхээр яллах, энэ талаарх сургалтыг хууль сахиулах байгууллагын ажилтнуудын дунд явуулах;

### **Хүүхэд**

- з. Гэр бүлийн болон хүүхдийн бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхийн тулд сургууль, гэрт нь хүмүүжил олгох зорилгоор хүүхдэд бие махбодийн шийтгэл хүлээлгэх буруу болохыг ойлгуулах, аливаа хүчирхийллийн хэлбэрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах талаарх олон нийтийн боловсрол, ойлголтыг нэмэгдүүлэх; Энэ тухайд Хүүхдийн эрхийн тухай хорооны зөвлөмжийг анхааралдаа авах;
- и. Палермогийн протоколын зүйл заалтуудыг зөрчихгүй биелүүлэхийн үүднээс хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийн цар хүрээг Хүүхдийн эрхийн талаарх хорооны зөвлөмжид нийцүүлэн өргөтгөх;
- й. Хөдөө орон нутагт амьдарч байгаа хүүхдүүдийн нийгмийн суурь үйлчилгээ хүртэх боломжийг сайжруулах, хот суурин дахь шилжин ирэгсдийн бүртгэлийн шат дамжлагыг хөнгөвчлөх замаар нийгмийн бүх хэсгийн хүүхдүүдийг боловсрол эзэмших тэгш боломжоор хангах; Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн сургалт олгох, уламжлалт сургалтыг орлох өөр бусад сургалтын хэлбэрээр боловсрол олгох нэмэлт арга хэмжээ авах;
- к. Хүүхэд хамгааллын асуудлыг хөгжлийн хөтөлбөрт илүү сайн тусгаж өгөхийн тулд холбогдох НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран тусгай ажлын хэсэг байгуулах;
- л. Хаягдмал, өнчин, орон гэргүй хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын нөхцлийг сайжруулах зорилгоор үнэлгээ хийх, энэ асуудлаар оролцогч талууд, түүний дотор хүүхэд, залуучуудтай зөвлөж хэлэлцүүлэг өрнүүлэх; Мөн

Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 3 дугаар зүйлд заасны дагуу тэдний гэр бүлд тулгарсан эд материалын гачигдлыг нь шийдвэрлэх замаар хүүхдүүдийг эцэг, эх буюу хамаатан садан дээрээ эргэн очиход шаардлагатай арга хэмжээ авах;

- м. Хүүхдийн хөдөлмөрийг зогсоож, тэдний сургуульд эргэн суралцах нөхцлийг хангахын үүднээс хүүхдүүд болон гэр бүлийг нь чадавхжуулах зорилготой Хүүхдийн хөдөлмөрийг арилгах олон улсын хөтөлбөр болон Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх, үндэсний хороо байгуулах зэргээр хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх үр нөлөөтэй арга хэмжээ авах;

### **Хөгжлийн бэрхшээлтэй иргэд**

- н. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид нэгдэн орсны дагуу Монгол Улсын хүлээн авсан үүрэг, амлалтад нийцүүлэн дотоодын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, дотоодын хууль тогтоомжид тусгагдаагүй конвенцийн гол зарчим, хэм хэмжээг тодорхойлох тусгай ажлын хэсгийг байгуулах асуудлыг анхааралдаа авах;
- о. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээ тэгш хүртэхэд шаардлагатай арга хэмжээ авч, Конвенцийн 9 дүгээр зүйлд заасны дагуу барилга байшин, зам, тээвэр болон сургууль, эмнэлэгийн газар, ажлын байр зэрэг бүх төрлийн гаднах болон доторх байгууламжид хүртээмжтэй байхад нь учирч буй саад, тотгорыг устгах;
- ө. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, ялангуяа хөдөө орон нутагт амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд өөрсдийн амьдарч буй орчиндоо бусадтай адил тэгш байх үндсэн дээр тусгай, үнэ төлбөргүй, чанартай, бага болон дунд боловсрол эзэмших боломжийг нь хангах гэсэн хууль эрх зүйн заалтыг хэрэгжүүлэх;
- п. НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй хамтран одоо мөрдөгдөж буй хууль тогтоомжид мониторинг хийх, дагаж мөрдүүлэх, нийгмийн бодлогод хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хэрхэн бодитой тусгуулах боломжийг тодорхойлох зорилгоор үнэлгээ хийх;

### **Үндэстний цөөнх**

- р. Үндэстний цөөнх хүн амын бусадтай адил тэгш байх үндсэн дээр эрхээ эдлэх бололцоог хангах, үүн дотор үндэстний цөөнхийн хэл дээр ном сурах бичгээр хангагдах, мэдээлэл хүлээн авах бололцоог олгосон соёлын болон боловсролын бодлого боловсруулан хэрэгжүүлэх;
- с. Төрөөс хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хараат бус мониторинг, үнэлгээ хийх зэрэг Хүний эрхийн үндэсний комиссоос гаргасан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх;
- т. Уугуул болон овог аймгийн хүмүүсийн эрх зүйн байдлыг хүлээн зөвшөөрсөн



- Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 169 дүгээр конвенцийг соёрхон батлах;
- у. 1954 оны Апартейдын эрх зүйн байдлын тухай конвенц болон 1961 оны Харьяалалгүй хүмүүсийн тоог бууруулах тухай конвенцид нэгдэн орж, харьяалалгүй болохоос урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах зорилгоор үндэсний хууль тогтоомж, бодлогыг цогцоор нь хянаж үзэх; НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал хариуцсан Дээд комиссарын газартай хамтран өмнө нь Монгол Улсын харьяат байсан хүмүүсийн бүртгэлийн ажиллагааг сайжруулах, Монгол Улсын харьяаллаа сэргээх журмыг хөнгөвчлөх замаар харьяалалгүй иргэдийн асуудлыг шийдвэрлэх;

### **Малчид**

- ү. Шаардлагатай тохиолдолд өөр ажил эрхлэх бололцоогоор хангахын тулд малчид, ялангуяа залуу малчдад зориулан ур чадвар олгох сургалт явуулах механизм бий болгох;
- ф. Бүх аймаг, сумдад эрүүл мэндийн халамж, боловсрол, ундны ус, ариун цэврийн байгууламж зэрэг чанартай нийгмийн суурь үйлчилгээний хүртээмжийг бий болгох, хүн амын энэ хэсгийн хүртээмжийн өнөөгийн түвшинг үнэлэх цогц судалгаа явуулсны үндсэн дээр сайжруулах тодорхой арга хэмжээ төлөвлөх;

### **Шилжин суурьшигчид**

- х. Бүртгэлийн удаашралтай байдлаас болж нэг ч хүнийг нийгмийн суурь үйлчилгээнээс орхигдуулахгүй байлгахын тулд хот орчмын суурьшилд байгаа орон нутгийн шилжин ирэгсдийг бүртгэх бүртгэлийн ажиллагааг сайжруулах;
- ц. Шилжин ирэгсдийг эрхийн талаар мэдээлэлтэй болгож, шинэ орчинд дасан зохицоход нь туслах мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх аян өрнүүлэх;
- ч. Нутгийн засаг захиргааны байгууллагуудыг хот суурин газарт ирсэн шилжин ирэгсдэд нийгмийн суурь үйлчилгээ хүргэх чадамжтай байлгах үүднээс шаардлагатай хөрөнгө нөөцөөр хангах;

### **ХДХВ/ДОХ-той амьдарч буй хүмүүс**

- ш. ХДХВ/ДОХ-той амьдарч буй хүмүүсийн амсаж буй алагчлал, гутамшиг доромжлолыг багасгахын тулд ХДХВ/ДОХ-оос сэргийлэх тухай хуульд оруулсан сүүлийн нэмэлт, өөрчлөлтийг бүрэн хэрэгжүүлж ажиллах;
- щ. Амьдралын бүх хүрээнд оролцохдоо эрүүл мэндийн байдлаар ялгаварлан гадуурхагдахаас хамгаалах, түүнийг засч залруулах үр нөлөөтэй механизм бий болгох; ХДХВ-той амьдарч буй хүмүүсийг ажлын байранд үл ялгаварлах тухай нэмэлт, өөрчлөлтийг хуулинд оруулж, хөдөлмөр эрхлэх нөхцлийг нь хангах;
- ь. ХДХВ/ДОХ-той амьдарч буй хүмүүс эрхээ бүрэн дүүрэн эдлэх, бусадтай адил тэгш үйлчилгээ хүртэх боломжийг хангахын үүднээс бүх оролцогч талтай хамтран өмнө нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг гүйцэтгэж байсан ХДХВ/ДОХ-ын асуудлаар Үндэсний хороог дахин байгуулах буюу ижил төрлийн байгууллагыг шинээр байгуулах;

- ы. ХДХВ/ДОХ-той амьдарч буй хүмүүсийн амсаж буй гутаан доромжлолыг багасгаж, арилгахын тулд олон нийтийн дунд мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх аян өрнүүлэх, ХДХВ/ДОХ-той амьдарч буй хүмүүсийг ялгаварлан гадуурхахыг хориглох, нууцыг нь хамгаалах үүднээс эрүүл мэндийн халамжийн байгууллагуудад сургалт зохион байгуулах;

#### **Бэлгийн цөөнх**

- ь. Лейсбиян, гей, бисексуал, трансжендэр (ЛГБТ) хүмүүсийн эрхийг хамгаалах үүднээс тэдний эсрэг үйлдсэн гэмт хэргийг шударгаар, сайтар мөрдөн шалгах, хэрэгжихүйц хууль тогтоомж гаргах;
- аа. ЛГБТ хүмүүсийг шийдвэр гаргах түвшинд бүрэн дүүрэн оролцохыг идэвхижүүлэх, боловсрол, эрүүл мэндийн халамж зэрэг нийгмийн үйлчилгээ хүртэхэд үл ялгаварлан гадуурхах түгээмэл зарчмыг хэрэгжүүлэх, энэ зарчмыг зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох үр нөлөөтэй механизмтай байх;
- э. Хууль сахиулах байгууллагын ажилтнуудад ЛГБТ бүлгийн эсрэг түгээмэл гардаг жендэрийн хүчирхийллийн талаар сургалт явуулах;
- ю. Ядуу нөхцөлд амьдарч байгаа иргэд тусгайлсан эрхээ эдлэхэд тулгарч буй бэрхшээлүүд:

#### **Нийгмийн хамгаалал**

- а. Нийгмийн хамгааллын цогц бүтэц, тогтолцоог бий болгох үүднээс энэ тайлангийн А хэсгийн 6 дугаар бүлэгт орсон нийгмийн аюулгүй байдал, хамгааллын талаарх зөвлөмжүүдийг анхаархалдаа авахыг Засгийн газарт зөвлөж байна;
- б. Нийгмийн хамгааллын өнөөгийн тогтолцоог улс төрийн нөлөөнөөс ангид байлгах;
- в. Зорилтот бүлгүүдийг тодорхойлох аргуудыг хэрэглэхэд бүх нийтийг хамарсан нийгмийн хамгаалал бий болгох зарчмыг баримтлах;
- г. Зорилтот бүлгүүдийг тодорхойлох аргуудыг хэрэглэхэд ул суурьтай, бодитоор хандах, ил тод, жендэрийн мэдрэмжтэй байх, орхигдуулах алдаанаас зайлсхийх;
- д. Нийгмийн хамгааллын тогтолцооны хууль тогтоомжуудыг батлах, эрх зүйн орчинг бий болгох, хэрэгжүүлэх урт хугацааны стратеги боловсруулах, хүрэлцээтэй, зохих санхүүжилтийг олгох, урт хугацаанд ажиллах институт байгуулж бэхжүүлэх;
- е. Ялгаварлан гадуурхахгүйгээр нийгмийн үйлчилгээ тэгш хүртэх бололцоог хангах, тогтолцооны ялгаварлан гадуурхалд өртөмтгий эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, цөөнх, ахмад настнуудын нийгмийн хамгааллын үйлчилгээг бүрэн хүртэхэд чиглэсэн бодлогын арга хэмжээ авах;
- ё. Нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдэд мониторинг, үнэлгээ хийх үүднээс хүйс, нас, яс үндэс, хөгжлийн бэрхшээлтэй байдлын талаар тоо баримт цуглуулах, дүн шинжилгээ хийж, боловсруулах;

### **Орон сууц**

- ж. Нийгмийн бүх гишүүд, түүний дотор хүн амын эмзэг хэсгийг орон сууцаар хангахад шаардлагатай биет дэд бүтцийг бий болгох;
- з. Шаардлага хангасан орон сууцгүй иргэдийн хэрэгцээг үнэлэх, орон сууц барих буюу орон сууцны нөхцлөө сайжруулахад нь санхүүгийн туслалцаа үзүүлэх зэргээр гэр хорооллын нөхцлийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлдэг механизм бий болгоход холбогдох НҮБ-ын байгууллагууд, иргэдтэй хамтран ажиллах;

### **Эрхээ хамгаалуулах**

- и. Хууль зүйн туслалцааны тухай хуулийг нэн даруй батлаж, түүнийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийн болон хүний нөөцийг хуваарилж өгөх;
- й. Шаардлагатай хөрөнгө нөөцийг хуваарилж, чадвартай сайн хуульчдаар хүний нөөцийг нь бүрдүүлэх, тэдэнд хангалттай цалин урамшуулал олгох замаар хууль зүйн туслалцаа үзүүлэх төвүүдийг чадавхжуулж, ядуу иргэдэд хүрч үйлчлэх боломжийг нь нэмэгдүүлэх;
- к. Хууль зөрчиж, гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн эрхийг хүндэтгэн хамгаалах, НҮБ-ын Хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн чиглэлийг мөрдөх;

## 10.5 НҮБ–ЫН ХҮНИЙ ЭРХ БА ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН ТУСГАЙ ИЛТГЭГЧ ЖОН НОКСИЙН ТАЙЛАН<sup>121</sup>

### I. Оршил

1. Тусгай Илтгэгч Жон Х.Нокс нь Засгийн газрын урилгаар 2017 оны 9–р сарын 19–өөс 27–ны өдрүүдэд хүний аюулгүй, цэвэр, эрүүл, тогтвортой орчинд амьдрахтай холбоотой эрхийг хангах үүргийн асуудлаар Монгол Улсад айлчлал хийсэн. Тус айлчлалын зорилго нь Монгол Улс байгаль орчноо хамгаалахтай холбоотой хүний эрхийг хэрхэн хэрэгжүүлж буйг судлах, ололт амжилтыг тодорхойлж байгаль орчинтой холбоотой хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалахад тус улсад тулгарч буй асуудлуудад анхаарах зэрэг байсан.

2. Тусгай Илтгэгч нь айлчлалынхаа үеэр төрийн албан хаагчид, эрдэмтэд, хуульчид, оюутнууд, иргэний нийгмийн болон хувийн хэвшлийн төлөөлөл, Азийн Хөгжлийн Банк болон Дэлхийн Банкны төлөөлөлтэй тус тус уулзсан. Эдгээр уулзалтуудын ихэнх нь нийслэл Улаанбаатар хотод зохион байгуулагдсан бөгөөд Тусгай Илтгэгч мөн Налайх дүүрэг, Төв аймгийн Заамар суманд<sup>122</sup> ажилласан. Тусгай Илтгэгч нь айлчлалынхаа үеэр Байгаль орчин, аялал жуулчлалын яам зэрэг төрийн байгууллагуудын албан хаагчид болон Гадаад харилцааны яам, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газрын төлөөлөгчидтэй уулзсан. Мөн Тусгай Илтгэгч Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны дарга болон Дээд Шүүхийн шүүгчтэй уулзалт хийсэн. Тэрээр Улаанбаатар хотын түвшинд Захирагчийн ажлын албаны албан хаагчид, Нийслэлийн Ерөнхий Прокурор, Заамар сумын захиргааны албан хаагчидтай уулзсан. Мөн Хүний эрхийн Үндэсний Комисстой уулзалт хийж, тус Комиссын зохион байгуулсан олон нийтэд нээлттэй лекц болон хэлэлцүүлэгт оролцсон.

3. Тусгай Илтгэгч түүнийг урьж Монгол Улсад ажиллах нөхцлийг бүрдүүлэн айлчлалын туршид хамтран ажилласанд нь Засгийн газарт талархал илэрхийлж байна. Мөн тэрээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Суурин Зохицуулагч болон Монгол Улсад ажиллаж байгаа НҮБ–ын багт талархал илэрхийлж байна.

4. Тусгай Илтгэгч нь Улаанбаатар, Налайх дүүрэг болон Заамар суманд түүнтэй уулзалт хийсэн хувь хүмүүс болон сонирхлын бүлгийн гишүүдэд тусгайлан талархаж байгаа бөгөөд Монгол Улсын байгаль орчныг хамгаалахад хичээн зүтгэж байгаа орон нутгийн төлөөлөгчид, байгаль хамгаалагчид, малчид, иргэний тэмцэгчид, ойн цагдаа, орон нутгийн оршин суугчид болон эцэг эхчүүдэд уулзахдаа тун таатай байснаа илэрхийлж байна.

<sup>121</sup> Энэхүү тайланг зөвхөн анх бэлтгэсэн хэл болох Англи хэлээр нийтэлсэн болно.

<sup>122</sup> Монгол Улс нь 21 аймаг, 1 хоттой, аймаг тус бүр нь сумдаас бүрддэг

## II. Эрх зүйн болон бодлогын тогтолцоо

### A. Эрх зүйн тогтолцоо

#### 1. Олон улсын эрх зүй

5. Монгол Улс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт зэрэг хэд хэдэн хүний эрхийн хэлэлцээрүүдийг соёрхон баталсан. Монгол Улс 2016–2018 онуудад Хүний Эрхийн Зөвлөлийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

6. Мөн Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын Суурь Конвенц, Парисын Хэлэлцээр, Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалын Протокол, Биологийн олон янз байдлын тухай Конвенци, Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенци, Мөнгөн усны тухай Минаматагийн Конвенци зэрэг байгаль орчны олон талт хэлэлцээрүүдийг мөн соёрхон баталсан.

#### 2. Дотоодын хууль, институтууд

7. Монгол Улсын Ерөнхийлөгч нь дөрвөн жилээр сонгогддог ба хууль тогтоомж санаачлах, хориг тавих болон зарлиг гаргах зэрэг бүрэн эрхтэй. Төрийн гүйцэтгэх дээд байгууллага болох Засгийн газар нь Үндсэн Хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хуулийн биелэлтийг хангах, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Засгийн газрын сайд нарыг Ерөнхий Сайд Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэн зөвшилдсөний үндсэн дээр Улсын Их Хурлаас томилдог.

8. Монгол Улсын парламент буюу Улсын Их Хурал нь нэг танхимтай бөгөөд 4 жилийн хугацаагаар томилогддог 76 гишүүдтэй. Улсын Их Хурал нь хууль баталж, нэмэлт, өөрчлөлт оруулдаг ба Ерөнхийлөгчийн хоригийг нийт гишүүдийн гуравны хоёрын саналаар хүлээж авах/татгалзах эрхтэй. Улсын Их Хурал нь Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны харьяалалд ажилладаг Тогтвортой хөгжлийн зорилтын дэд хороо болон Хууль зүйн байнгын хорооны харьяалалд ажилладаг Хүний эрхий дэд хороотой. Улсын Их Хурал нь мөн Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлснээр Ерөнхий Сайдыг томилдог.

9. Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэний зайлшгүй эдлэх үндсэн эрх, эрх чөлөөний тухай заасан байдаг. Амьд явах эрхийн дараа, жагсаалтын хоёрдугаарт эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг багтаасан байдаг.

10. Монгол Улс нь байгаль орчинтой холбоотой олон хуультай. Үүнд: Байгаль орчны стандарт, хяналт, судалгаа, мэдээлэл, хяналт шалгалт, иргэний нийгмийн оролцоо зэрэг асуудлуудыг зохицуулсан Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Агаарын тухай хууль, Усны тухай хууль, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, Тусгай Хамгаалалттай Газар Нутгийн тухай хууль болон газар нутгийг уул уурхайн үйл ажиллагаанаас хамгаалахыг зорилготой Гол,

мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль (Монгол Улсад Урт нэртэй хууль хэмээн танигдсан) зэрэг багтана.

11. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу байгаль орчны хамгаалах болон байгалийн баялгийг удирдах үйл явцад сонирхлын бүлгүүдийн оролцоог зохицуулсан. 2015 онд батлагдсан Захиргааны Ерөнхий Хуульд төрийн албан тушаалтнуудын шийдвэрийг давж заалдах иргэн, хуулийн этгээдийн эрхийг болон төрийн удирдлага дахь ерөнхий болон процессын асуудлуудыг зохицуулсан. Эрүүгийн Хуульд байгаль орчны эсрэг гэмт хэргийн талаар бүлэг тусгагдсан.

12. Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь Монгол Улсын байгаль орчныг хамгаалахад хяналт тавьдаг үндсэн байгууллага нь юм. Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар нь Шадар сайдын ажлын албаны дор байгаль орчны стандартуудыг дагаж мөрдөж байгаа эсэхийг хянадаг газар юм.

13. 2000 онд Улсын Их Хурлаас байгуулагдсан Хүний эрхийн Үндэсний Комисс нь хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлдэг. Мөн тус байгууллага нь хүний эрхийн зөрчлийн талаарх гомдлыг хянаж, төрийн байгууллагуудад санал, зөвлөмж гаргадаг.

### **Б. Бодлогын тогтолцоо**

14. Монгол Улс нь тогтвортой хөгжлийг өөрийн урт хугаацааны зорилго хэмээн тодорхойлсон. 2013 онд тус улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын тогтвортой хөгжилд шилжихийг дэмжсэн Ногоон Эдийн засгийн төлөөх Түншлэл хөтөлбөрт нэгдсэн дэлхийн анхны улс болсон. 2014 онд Улсын Их Хурал Ногоон Хөгжлийн Бодлогыг баталсан бөгөөд Засгийн Газар нь 2016–2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан.

15. 2016 онд Монгол Улс тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-ыг баталсан ба энэхүү баримт бичигт баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 2020 он гэхэд 80 хувьд, 2030 он гэхэд 90 хувьд хүргэж, 2020 он гэхэд хүн амын 40 хувийг, 2030 он гэхэд 80 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох, 2020 он гэхэд тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нийт газар нутгийн 25 хувьд, 2030 он гэхэд 30 хувьд хүргэх, Улаанбаатарын агаарын бохирдлыг 2020 он гэхэд арилгах зэрэг зорилтуудыг тусгасан.<sup>123</sup>

### **III. Байгаль орчны нөхцөл байдал**

16. Монгол Улс нь баруун хэсгээрээ Алтайн нуруунд уулархаг хэсэгтэй, хойд хэсгээрээ шилмүүст тайга, өмнөд хэсгээрээ говь цөл, улсын ихэнх хэсгээр тал бэлчээрийг багтаасан олон төрлийн эрс тэс экосистемтэй. Тус улс нь дэлхийд тоо нь цөөрч буй олон тооны зэрлэг амьтадтай. Тухайлбал, Дорнын Сэрэнгэти<sup>124</sup> хэмээн нэрлэгдсэн Дагуурын

<sup>123</sup> Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030. [www.un-page.org/files/public/20160205\\_mongolia\\_sdv\\_2030.pdf](http://www.un-page.org/files/public/20160205_mongolia_sdv_2030.pdf) хаягаас үзэх боломжтой.

<sup>124</sup> Олон улсын Байгаль хадгалах Холбоо, “Дорнын Сэрэнгэти”, 2013 оны 8-р сарын 9. [www.iucn.org/content/serengeti-east](http://www.iucn.org/content/serengeti-east) хаягаас үзэх боломжтой.

талыг дэлхийд хамгийн унаган байдлаараа үлдсэн газар гэж болох бөгөөд Төв Азид олон тоогоороо нүүдэллэн амьдардаг туурайтан амьтдын бараг хамгийн сүүлчийн төлөөлөл гэж хэлж болох Монгол бөхөн байдаг.<sup>125</sup> Тус улсын намаг газар, голууд нь алаг тогоруу, цэн тогоруу, хун галуу, хонин тоодог зэрэг сая сая нүүдлийн шувуудын амьдардаг гол газар нь болдог.

17. Монгол Улс нь хэдэн мянган жил оршин тогтнож, өнөөдрийг хүртэл Монголчуудын үнэ цэнэ, аж амьдралыг тодорхойлсоор байгаа нүүдлийн мал маллах соёлоороо дэлхий дахинд танигдсан. Монголчуудын гуравны нэгээс дээш хувийг малчид эзэлдэг. Түүхийн явцад нүүдлийн соёл нь хүн төрөлхтнийг өөрсдийн болон тэдний мал сүрэг хамааралтай байдаг байгалийн экосистемтэй зохицож амьдрах шаардлагатай болгосон. Бэлчээрийн мал аж ахуй нь Монгол Улсын хүнд хэцүү газар зүйн нөхцөл байдал болон улирлын уур амьсгалын өөрчлөлтөд сайтар дасан зохицсон ба хагас хуурай, хуурай бэлчээрийг тогтвортой ашиглах амжилттай стратеги болсон юм. Хэдий тийм боловч сүүлийн жилүүдэд нүүдлийн мал аж ахуй болон түүний бэлчээрт үзүүлэх аюул занал нэмэгдсээр байна.

18. Гол аюул заналын нэг болох бэлчээрийн даац хэтрэх нь бэлчээрийн уян хатан байдлыг доройтуулж байна.<sup>126</sup> Монгол Улсын мал сүргийн тоо харьцангуй богино хугацаанд дунджаар 25 саяас 50 сая гаруйд хүрч хоёроос дээш дахин өссөн.<sup>127</sup> Мөн ижил хугацаанд ямааны нийт мал сүрэгт эзлэх хувь ихээхэн нэмэгдэж, 40 хувь хүртэл өссөн. Ямаа нь олон төрлийн ургамал идэж, үндсийг нь ухдаг учраас бусад төрөл зүйлээс хор хөнөөлтэй байдаг. Ямаа нь уламжлалт ёсоор Монголын мал сүргийн хамгийн чухал мал байгаагүй боловч тоо толгой нь ноолууран эдлэлийн эрэлт хэрэгцээнээс шалтгаалан өссөн.

19. Өөр нэгэн өсөн нэмэгдэж буй аюул занал бол уур амьсгалын өөрчлөлт. 1940–өөс 2014 оны хооронд Монгол Улсын агаарын дундаж температур 2°C-оос илүү хэмээр буюу дэлхийн дунджаас илүү нэмэгдсэн.<sup>128</sup> Засгийн газар нь уур амьсгалын өөрчлөлт нь зуны ган гачгийн дараа хүнд өвөл тохиож, хомстолд хүргэж, улмаар олон тооны амьтад үхэх, малчид хүнсний найдваргүй байдалд хүргэдэг үйл явдал болох зуд зэрэг байгалийн гамшгийн хүрээ болон давтамжийг нэмэгдүүлнэ хэмээн тооцоолж байна. Түүхийн явцад зуд ойролцоогоор арван жилд нэг удаа тохиодог байсан бол сүүлийн гучин жилийн хугацаанд энэхүү давтамж нь дөрвөөс цөөн жилд нэг удаа болж нэмэгдсэн.<sup>129</sup>

<sup>125</sup> ОХУ болон Монгол Улс, “Дагуурын газар нутаг: ЮНЕСКО-ийн Дэлхийн Соёлын болон Байгалийн Өвийн жагсаалтад оруулах санал”, 2017 оны 5–р сар, 5 дахь тал. [www.nhpfund.ru/files/Dauria-nomination.pdf](http://www.nhpfund.ru/files/Dauria-nomination.pdf) хаягаас үзэх боломжтой.

<sup>126</sup> Монгол Улс, “Үндэсний тавдугаар тайлан: Биологийн Олон янз байдлын тухай Конвенц”, 2014. [www.cbd.int/doc/world/mn/mn-nr-05-en.pdf](http://www.cbd.int/doc/world/mn/mn-nr-05-en.pdf) хаягаас үзэх боломжтой.

<sup>127</sup> 2015 онд Монгол Улсын малын тоо хэмжээнд ойролцоогоор 25 сая орчим хонь, 23 сая орчим ямаа, 4 сая орчим үхэр, 3 сая гаруй адуу, 400,000 орчим тэмээнээс бүрдэж байсан. НҮБ-ын Европын Эдийн Засгийн Комисс, (ЕЭЗК), Байгаль орчны үзүүлэлтийн тойм: Монгол Улс (төсөл), 2017 оны 11–р сар (ECE/CEP/185), 271 дэх тал. [www.unesc.org/fileadmin/DAM/env/epr/epr\\_studies/ECE.CEP.185\\_Eng.pdf](http://www.unesc.org/fileadmin/DAM/env/epr/epr_studies/ECE.CEP.185_Eng.pdf) хаягаас үзэх боломжтой. ЕЭЗК-ын тайлан нь Монгол Улсын байгаль орчны нөхцөл байдал, хууль тогтоомж, бодлогын талаар гаргасан дэлгэрэнгүй тойм юм. Өөрөөр дурдсанаас бусад тохиолдолд энэхүү тайланд дурдсан статистикуудыг дээр дурдсан тайлангаас авсан болно.

<sup>128</sup> Монгол Улс, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Монгол Улсын Уур амьсгалын хоёр дахь тайлан 2014, ЕЭЗК, Байгаль орчны үзүүлэлтийн тойм: Монгол Улс, 166–167 дахь тал.

<sup>129</sup> ЕЭЗК, Байгаль орчны үзүүлэлтийн тойм: Монгол Улс, 271 дэх тал.

20. Уул уурхай бол Монголын байгаль орчныг бохирдуулагч бас нэгэн эх үүсвэр юм. Одоогийн байдлаар Монгол Улсын газар нутгийн 7 орчим хувьд ашигт малтмалын хайгуулын болон олборлолтын тусгай зөвшөөрөл олгосон. Уул уурхай улс орны эдийн засагт ихээхэн хувь нэмэр оруулдаг боловч агаар, ус бохирдуулах, газар доорх усны эх үүсвэрийг хэтрүүлэн хэрэглэх, бэлчээрийн газрыг сүйтгэх зэрэг байгаль орчны ноцтой асуудлуудыг үүсгэдэг.

21. Эдгээр хүчин зүйлс нь Монголчуудын уламжлалт байгальтай харьцах харилцаанд аюул занал учруулж байна. Эдгээр нь биологийн олон янз байдал алдагдахад нөлөөлөхөөс<sup>130</sup> гадна нүүдлийн мал аж ахуйг хүндрэлтэй болгож олон тооны малчид болон тэдний гэр бүлийг хөдөөнөөс Улаанбаатар болон бусад төв суурин газарт амьдрахаар нүүхэд хүргэж байна. Өсөн нэмэгдэж буй хотын хүн ам нь улмаар агаар болон усны бохирдол нэмэгдэхэд хүргэж байна. Энэхүү асуудлууд нь ялангуяа одоогоор 1.5 сая орчим буюу улсын нийт хүн амын бараг тал орчим хувь нь амьдардаг Улаанбаатар хотын хувьд ихээхэн хүндрэл учруулж байна. Улаанбаатар хотод оршин суугчдын 60 гаруй хувь нь гэр хороололд амьдардаг бөгөөд хүмүүс нь ихэнхдээ байшин, орон сууцнаас илүүтэйгээр гэрт амьдардаг учраас ингэж нэрлэсэн байдаг.<sup>131</sup> Гэр хорооллын оршин суугчид ихэвчлэн нүүрс болон бусад хатуу түлшийг ашигладаг учраас энэ нь ялангуяа өвлийн улиралд агаарын бохирдол нэмэгдэхэд ихээхэн нөлөөлдөг.

#### IV. Ололт амжилт ба тулгарч буй сорилтууд

22. Монгол Улсын түүхэн соёл болон түүхийн олон асуудлууд нь онцлог боловч тус улсад тулгарч буй ерөнхий сорилт нь бусад олон улсуудад тулгарч буй сорилтуудтай ижил төстэй байдаг. Өөрөөр хэлвэл байгалийн баялгаа ард иргэдийн амьдарч буй байгаль орчныг сүйтгэлгүйгээр хэрхэн хүн амын эдийн засгийн нөхцөл байдлыг үргэжлүүлэн сайжруулах замаар ашиглах вэ? Монгол Улс хэрхэн тогтвортой хөгжилд хүрэх вэ? гэдэг асуудлууд юм.

23. Хэдийгээр энэхүү асуултын тодорхой хариултыг зөвхөн Монголчууд өөрсдөө өгч чадах боловч хөгжил бодиттойгоор тогтвортой байхын тулд хүний эрхэд суурилсан байх ёстой гэдэг нь тодорхой. Хүний эрх болон байгаль орчныг хамгаалах асуудлууд нь хоорондоо харилцан хамааралтай, өөрөөр хэлбэл хүний эрхийг хэрэгжүүлэх нь байгаль орчныг хамгаалахад дэмжлэг үзүүлнэ, мөн аюулгүй, цэвэр, эрүүл, тогтвортой хүрээлэн буй орчин нь хүний эрхийг бүрэн эдлэхэд шаардлагатай нөхцөл нь юм. Улмаар төр нь хүний эрхийг хөхиүлэн дэмжихийн тулд байгаль орчныг хамгаалах үүрэг хүлээдэг (A/HRC/37/59–г харна уу).

24. Эдгээр үүргүүдэд хүний эрхэд үзүүлэх байгаль орчны нөлөөллийг үнэлэх, байгаль орчны талаар мэдээллийг нийтэд нээлттэй болгох зэрэг процессийн үүргүүд, байгаль орчны шийдвэр гаргах ажиллагаанд оролцоог хангах, байгаль орчинд үзүүлсэн хор

<sup>130</sup> Байгалийн төлөөх Дэлхий нийтийн сан, Монгол Улс дахь Хөтөлбөрийн Оффис, Монгол Улс дахь биологийн олон янз байдлыг хамгаалахын тулд хийдлийг нөхөх нь, 2010 оны 8–р сар.

<sup>131</sup> Гэр бол ихэнхдээ эсгийгээр бүрсэн, хялбар зөөвөрлөх боломжтой дугуй майхан юм. Гэр нь урт удаан хугацаанд нүүдлийн мал аж ахуйн соёлын залшгүй хэсэг байсан.



нөлөөнд эрх сэргээх арга хэрэгслүүдийг нээлттэй болгох зэрэг багтана. Хөгжлийн болон байгаль орчны бодлогын нөлөөнд хамгийн их өртөх бүлгүүдийг мэдээлэл олж авах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шийдвэр гаргах процесст оролцох боломжоор хангах нь хүний эрхэм чанар, тэгш байдал, эрх чөлөөг хөхиүлэн дэмжихээс гадна бүх хүний эрхийг хэрэгжүүлсний үр дүнд тэдгээрийн нөлөөнд хамгийн их өртөж буй бүлгүүдэд илүү ашиг тустай байхаар бодлогоо тодорхойлж, үйл ажиллагааныхаа үр нөлөөг нэмэгдүүлнэ.

25. Байгаль орчинд үзүүлэх хор нөлөөнөөс хамгаалж, байгаль орчноос хамааралтай хүний эрхүүдийг бүрэн ойлгож ухамсарлахын тулд төр мөн аюулгүй, цэвэр, эрүүл, тогтвортой орчинд амьдрах хууль зүйн болон институцийн тогтолцоог бий болгож, хадгалах шаардлагатай (A/HRC/37/59, Хавсралт, Тогтолцооны зарчим 11–г үзнэ үү). Онолын үүднээс байгаль орчны стандартуудыг хүний үзүүлэх бүхий л байгаль орчны нөлөөллөөс хамгаалахуйц түвшинд тогтоож, хэрэгжүүлнэ. Гэсэн хэдий ч хязгаарлагдмал хөрөнгө нь эрүүл амьдрах, хүнс болон усны эрх болон бусад эдийн засаг, нийгэм, соёлын эрхүүдийг бүрэн хэрэгжүүлэх асуудлыг хүндрэлтэй болгодог. Төрийн бүхий л боломжит арга хэлбэрээр<sup>132</sup> эдгээр эрхүүдийг бүрэн хэрэгжүүлэх үүрэг нь энэхүү зорилтод чиглэсэн нарийвчлан боловсруулсан, бодитой, зорилтот арга хэмжээнүүдийг авахыг шаарддаг боловч төр боломжит хөрөнгөөсөө хамааран тохиромжтой арга хэлбэрүүдийг сонгох тал дээр өөрийн үзэмжээр ханддаг.<sup>133</sup>

26. Монгол Улс байгаль орчны сайн стандартуудыг баталсан. Тус улс хүний эрх болон байгаль орчин хамгаалалт хоорондын хамаарлыг Үндсэн хуулиндаа эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхэнд тусгаж хүлээн зөвшөөрсөн. Мөн тус улс агаарын бохирдол, ашигт малтмал зэрэг нарийвчилсан байгаль орчны талаар хуулиудыг батлан гаргасан. Мөн 2012 онд тус улс зүйл заалтуудыг нь сайжруулж, илүү уялдаа холбоотой, хооронд нь илүү нийцүүлэх зорилгоор байгаль орчны хууль тогтоомжуудаа дахин хянасан. Хэдийгээр зарим нэгэн дутагдал байсаар байгаа боловч гол асуудал нь стандартуудын чанарт бус тэдгээрийн хэрэгжилтэд байна.

27. Үр дүнтэй байхын тулд байгаль орчны стандартуудыг хэрэгжүүлэх шаардлагатай (A/HRC/37/59, Хавсралт, Тогтолцооны зарчим 12–ыг үзнэ үү). Төрийн албан тушаалтнууд өөрсдийн үйл ажиллагаандаа холбогдох байгаль орчны стандартуудыг дагаж мөрдөж, хувийн хэвшлийн оролцогчид болон төрийн албан тушаалтнууд эдгээр стандартуудыг зөрчихөөс урьдчилан сэргийлж, мөрдөн шалгаж, хариуцлага хүлээлгэж, засварлах замаар стандартуудыг дагаж мөрдөж байгаад хяналт шинжилгээ хийж, үр дүнтэйгээр хэрэгжүүлэх шаардлагатай.

28. Тусгай Илтгэгч айлчлалынхаа явцад хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлж чадахгүй байгаа олон жишээ сонссон. Үүний нэг нь усны бохирдол, тэр тусмаа Улаанбаатар хотын орчим байдаг Туул голын бохирдол юм. Тусгай Илтгэгч хотын ойролцоох голын дэргэд ил хаясан нүүрсний үнсэн овоо болон урсгалын дээд болон доод хэсэгт уул уурхайн бохирдол байгаатай тааралдсан. Мөн тэрээр бохир усыг шууд гол руу асгадаг тохиолдлуудын талаар сонссон. 2012 онд батлагдсан Усны төлбөрийн тухай

<sup>132</sup> Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, 2 (1) дүгээр зүйл.

<sup>133</sup> Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн зөвлөл, Гишүүн улс орнуудын үүргийн шинж чанарын талаар ерөнхий тайлбар № 3 (1990).

хуулиар хаягдал ус асгасны төлбөрийг тогтоосон боловч шаардлагатай дагалдах хууль тогтоомжийг батлаагүйн улмаас 2017 оны 6–р сарын байдлаар энэхүү хууль хэрэгжиж эхлээгүй байна.

29. Бас нэг жишээ бол байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ юм. Монгол Улс төлөвлөж буй төслүүдийн боломжит нөлөөг үнэлэхээс гадна 2012 онд хоёр шинэ төрлийн үнэлгээг нэвтрүүлсэн. Үүнд: боловсруулагдаж буй бодлого, хөгжлийн хөтөлбөр болон төлөвлөгөөний стратегийн байгаль орчны үнэлгээ болон тодорхой бүс нутагт хэрэгжиж буй төслүүдийн үр нөлөөг үнэлэх цогц үр нөлөөний үнэлгээ зэрэг болно. Гэсэн хэдий ч 5 жилийн дараа буюу 2017 оны байдлаар стратегийн байгаль орчны үнэлгээний практик хэрэгжилт эхлээгүй, харин цогц үр нөлөөний үнэлгээг зөвхөн хоёр тохиолдолд хийсэн байна.<sup>134</sup> Мөн Тусгай Илтгэгч Засгийн газарт төслийн санал болгож байгаа талын хийж өгсөн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлангуудыг ихэнхдээ өөр тайлангуудаас хуулбарласан байдаг ба улмаар хэлэлцэгдэж буй Говь цөл дэх уул уурхайн үйл ажиллагааны үнэлгээний тайланд хойд хил орчмын шилмүүст ойн үр нөлөөний анализыг багтаасан байх магадлалтай байдаг гэж сонссон.

30. Энэхүү асуудлуудын зарим нь хангалттай хөрөнгө байхгүйгээс болсон нь ил байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны төсөв 2011 онд засгийн газрын нийт төсвийн 1.9 хувиас 2016, 2017 онд ердөө 0.5 хувь болж, сүүлийн жилүүдэд ихээхэн буурсан нь сэтгэл зовиносон асуудал болж байна. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Европын Эдийн засгийн Комисс (ЕЭЗК)–ын тайлагнаснаар тус яамны байгаль орчны үнэлгээ болон хяналт шинжилгээний алба нь ердөө зургаан албан хаагчтай, тэдгээр нь тус бүр нэгээс дөрвөн жилийн ажлын туршлагатай боловч байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хяналт тавих чиг үүрэгтэй байна. Сар бүр тэд 50–иас 60 төсөлд ерөнхий дүгнэлт гаргаж, нэмэлт 30–аас 40 төсөл хууль зүйн шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянадаг. ЕЭЗК нь уг ажлын өндөр ачаалал нь тайлан нэг бүрийг нэг бүрчлэн нарийн шалгах боломжгүй болгоход хүргэдэг хэмээн дүгнэсэн байна.<sup>135</sup>

31. Үүний адил хөрөнгөний дутагдалтай холбоотой саад бэрхшээлүүд бусад хууль зүйн шаардлагуудын хэрэгжилтийг мөн хүндрүүлж байна. Тухайлбал, 2012 онд Монгол Улс үйл ажиллагаа нь байгалийн баялгийг ашиглахтай холбоотой бүхий л этгээдүүдийг хоёр жил тутамд нэг удаа байгаль орчны аудит хийхийг шаардаж, хууль тогтоомждоо өөрчлөлт оруулсан. 2013 онд аудитын аргачлалыг тодруулж, зөвшөөрөгдсөн хувийн аудиторундад тусгай зөвшөөрөл олгох асуудлыг зохицуулсан дагалдах хууль тогтоомжийг баталсан. Үүнээс хойш 25 орчим байгаль орчны аудитын фирм, 200 орчим хувь хүнд аудит хийх эрх олгосон. Гэсэн хэдий ч Яаманд байгаль орчны аудитад хяналт тавих үүрэг бүхий нэг л албан хаагч байдаг учир дүрэм, журмыг дагаж мөрдөөгүй тохиолдолд ногдуулах хариуцлагыг хүлээлгэж чадаахгүй байна. Улмаар ЕЭЗК бодит байдал дээр аудит нь хууль тогтоомжоос бус сайн дурын үүрэг хариуцлага эсвэл хөрөнгө оруулагчийн шахалтаас үүдэн гардаг хэмээн ойлгодог байна.<sup>136</sup>

32. Бусад агентлагууд болон газруудад ч ижил төрлийн асуудлууд тулгарч байна.

<sup>134</sup> ЕЭЗК, Байгаль орчны үзүүлэлтийн тойм: Монгол Улс, 26 дахь тал.

<sup>135</sup> Дээрхтэй адил, 71 дэх тал.

<sup>136</sup> Дээрхтэй адил, 64 дэх тал.

Тухайлбал, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар зөөврийн шинжилгээний тоног төхөөрөмжгүй ба хангалттай тооны албан хаагч байхгүй хэмээн мэдээлсэн.<sup>137</sup> Эрүүгийн Хуулинд хууль бусаар ашигт малтмал хайх, олборлох, хууль бусаар ан хийх, хууль бусаар мод бэлтгэх зэрэг хэд хэдэн байгаль орчны гэмт хэргүүдийг заасан боловч цөөн тооны хэрэгт шийтгэл хүлээлгэдэг талаар Тусгай Илтгэгч мэдээлсэн.

33. Дараах хэсэгт Тусгай Илтгэгч доорхи дөрвөн салбарууд байгаа ололт, амжилт сорилтуудыг дүгнэсэн: агаарын бохирдол, уул уурхай, байгаль хамгаалалт ба тусгай хамгаалалттай газар, мэдээлэл авах, олон нийтийн асуудалд оролцох, эдгээр эрхийг хамгаалах арга хэрэгслээр хангагдах эрх.<sup>138</sup> Эдгээр чиглэлээр Монгол Улс үр дүнтэй стандартууд, хууль тогтоомжуудыг баталсан боловч тэдгээрийг хэрэгжүүлэх, биелүүлэх явцад ноцтой хүндрэлүүдтэй тулгарч байна.

#### **А. Агаарын бохирдол**

34. Монгол Улсын хамгийн ноцтой байгаль орчны асуудал нь агаарын бохирдол. Улаанбаатар хотын хүрээлэн буй орчны агаарын нарийн ширхэгтэй тоосонцор (PM2.5) дунджаар жилийн 70  $\mu\text{g}/\text{m}^3$  байгаа нь Монгол Улсын агаарын чанарын стандарт (25  $\mu\text{g}/\text{m}^3$ )–аас өндөр байгаа бөгөөд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)–ын тогтоосон хэмжээ (10  $\mu\text{g}/\text{m}^3$ )–ээс давсан байна.<sup>139</sup> Хүхрийн диоксид болон азотын оксид зэрэг бусад бохирдуулагч нь мөн дотоодын болон олон улсын стандартуудаас давсан түвшинд байна.<sup>140</sup>

35. Энэхүү их хэмжээний агаарын бохирдол нь эрт нас баралтад хүргэдэг амьсгалын замын болон зүрх судасны өвчин үүсгэх аюултай тул хүний амьд явах, эрүүл байх эрхэд сөрөгөөр нөлөөлж байна. Улаанбаатар хот дахь гучаас дээш насны хүмүүсийн нас баралтын 10 хувь, нийт улс даяарх нас баралтын 4 хувь нь агаарын бохирдолтой холбоотой байх магадлалтай.<sup>141</sup> Эдгээр тоо баримт хэдийгээр өндөр боловч баримт доторх агаарын бохирдлын хэмжээг харгалзан үздэггүй бөгөөд хүүхдүүдэд агаарын бохирдлын үзүүлэх хор нөлөөг төдийлөн шалгадаггүй учраас тус асуудлын хүрээ дутуу дүгнэгдэж байгаа.

36. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан (ЮНИСЕФ) Улаанбаатарт жил бүр таваас доош насны 400 гаруй хүүхэд агаарын бохирдолтой холбоотой уушгины үрэвслээс болж нас бардаг гэсэн тооцоог гаргасан байна.<sup>142</sup> Хүүхэд насандаа агаарын бохирдолд өртөх нь мөн хожим уушиг, зүрх судасны өвчин, уушгины хорт хавдар зэрэг архаг өвчин тусах магадлалыг бий болгодог. 2017 онд Хүүхдийн Эрхийн Хорооноос нас

<sup>137</sup> Дээрхтэй адил, 65 дахь тал.

<sup>138</sup> Санаа зовоосон асуудлууд эдгээрээр хязгаарлагдахгүй боловч эдгээр асуудлууд нь Тусгай Илтгэгчийн айлчлалын үеэр хамгийн их анхаарал татсан сэдвүүд байв.

<sup>139</sup> ЕЭЗК, Байгаль орчны үзүүлэлтийн тойм: Монгол Улс, 354 дэх тал. 2.5 микрометр буюу түүнээс бага диаметртэй учраас нарийн тоосонцорууд уушгинд нэвтрэн орж, хүний эрүүл мэндэд богино болон урт хугацааны сөрөг нөлөө үзүүлэх боломжтой. ДЭМБ, хүрээлэн буй орчны агаарын бохирдол: Дэлхий нийтийн өвчлөлд өртөмтгий байдал болон хүндрэлийн үнэлгээ, 2016, 19 дэх тал.

<sup>140</sup> ЕЭЗК, Байгаль орчны үзүүлэлтийн тойм: Монгол Улс, 190 дэх тал.

<sup>141</sup> Дээрхтэй адил, 354 дэх тал.

<sup>142</sup> ЮНИСЕФ, “Монгол Улсад агаарын бохирдлын хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг ойлгож, шийдвэрлэх нь”, 2016 оны 6–р сар.

биед хүрсэн хойноо амьсгалын замын цочмог болон архаг өвчин, мөн уушгины үрэвсэлд хүргэх ургийн өсөлт буурах, дутуу төрөх, уушгины үйл ажиллагаа муудах зэрэг Монголын, тэр тусмаа Улаанбаатарын хүүхдүүдэд агаарын бохирдлын үзүүлэх нөлөөний талаар ихээхэн санаа зовниж буйгаа илэрхийлсэн.<sup>143</sup>

37. Агаарын энэхүү бохирдол нь хэд хэдэн эх үүсвэртэй. Эдгээрийн нэг нь бэлчээрийн даац хэтрэх, уур амьсгалын өөрчлөлт, газраа уул уурхайд алдах зэрэг ихэнхдээ байгаль орчны хүндрэлээс шалтгаалсан малчдын Улаанбаатар болон бусад төв суурин газар руу шилжин суурьших явдал юм. Байгаль орчны дэд бүтэц өсч буй хүн амын хэрэгцээ шаардлагад хүрэлцэхгүй байна. Малчид хот суурин газар ирээд ихэвчлэн дулаалга муутай гэрт цахилгаан болон бусад дэд бүтцэд холбогдоогүй газар амьдардаг. Гэр хорооллын оршин суугчид өвлийн улиралд гэрээ дулаацуулах, хоолоо хийх зорилгоор хатуу түлш ашигладаг нь агаарын бохирдлыг нэмэгдүүлэх хүчин зүйл болдог.

38. Гэр хорооллын агаарын бохирдол дахь нөлөөг шийдвэрлэх зорилгоор тодорхой алхмуудыг хийсэн боловч аль нь ч мэдэгдэхүйц үр дүнд хүрээгүй. Тухайлбал, 2012 оны Агаарын тухай хуулийн дагуу Цэвэр агаар санг байгуулж, гэр хорооллын оршин суугчид зуух болон агаар шүүгч хэрэглэх, сайжруулсан түлшн худалдан авахад нь зориулсан тэтгэмжид нийт 45 сая ам.долларыг хуваарилсан. Гэвч энэхүү санг хожим нь татан буулгасан. Дэлхийн Банк “цэвэр зуух” санаачилгыг дэмжсэн ба энэхүү санаачилга нь Улаанбаатарын гэр хорооллуудад 130,000 гаруй бага утаа ялгаруулдаг зуухыг нийлүүлсэн.<sup>144</sup> Гэвч ийм зуухыг зах зээлд тогтвортой үргэлжлүүлэн нийлүүлж чадаагүй ба энэ санаачилга зогссон гэдэг мэдээллийг Тусгай Илтгэгч авсан. Улаанбаатар хотын захиргаанаас нэн ядуу хүмүүст чанартай нүүрс олгох, цахилгааны төлбөрт хөнгөлөлт олгох зэргээр гэр хорооллоос гарч буй агаарын бохирдлыг бууруулах хүчин чармайлтыг гаргасаар байна.<sup>145</sup>

39. Мөн хотын захиргаа хот руу шилжин суурьших хөдөлгөөнд хязгаарлалт тогтооно гэдгээ зарласан. Ингэж хот руу чиглэх нүүдлийг хязгаарлахыг оролдсон нь аль нэг улсын нутаг дэвсгэр дээр хууль ёсоор оршин сууж байгаа аливаа хүн тухайн нутаг дэвсгэр дотор чөлөөтэй шилжин суурьших, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхийг заасан Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт (12-р зүйл)-ыг зөрчиж байна. Энэхүү эрхийг зөвхөн үндэсний аюулгүй байдал, нийтийн хэв журам, нийтийн эрүүл мэнд буюу ёс суртахуун, бусдын эрх, эрх чөлөөг зөрчсөн тохиолдолд хязгаарлахыг зөвшөөрдөг. Илүү цэвэр дулааны эх үүсвэрийг бий болгох, гэрт амьдардаг иргэдийг сайн дулаалга бүхий орон сууц руу шилжүүлэх зэрэг нь агаарын бохирдлын шийдэл болж байгаа тул Улаанбаатар руу шилжих хөдөлгөөнийг шууд хорих нь зөвхөн нийтийн эрүүл мэндийг хамгаалах шаардлагатай гэсэн үндсэн дээр хэрэгжүүлэх боломжгүй юм.

40. Улаанбаатар болон Монгол Улсын бусад төв суурин газруудын агаарын бохирдлын талаар ярихад дан ганц гэр хороолол дээр төвлөрөх нь зохисгүй; агаарын бохирдолд өөр эх үүсвэрүүд мөн нөлөөлдөг. Улаанбаатар ДЦС-2, ДЦС-3, ДЦС-4 гэсэн

<sup>143</sup> CRC/C/MNG/CO/5, пара. 34. Мөн E/C.12/MNG/CO/4, пара. 26.

<sup>144</sup> Дэлхийн Банк, “Монгол Улсын үндэсний бага утаа ялгаруулдаг зуухны стратеги: илүү цэвэр зуухнуудын тогтвортой зах зээл рүү шилжих шилжилтийг бүрэн гүйцэт болгох нь”, 2015

<sup>145</sup> Х. Аминаа, “Үндэсний агаарын бохирдлыг бууруулах хөдөлгөөнийг эрчимжүүлэх талаар”, Монцамэ мэдээллийн агентлаг, 2017 оны 7-р сарын 2. Мөн “Үндэсний Байгаль орчны бохирдлыг бууруулах зөвлөл хуралдав”, Монцамэ мэдээллийн агентлаг, 2017 оны 8-р сарын 2.

нүүрсээр галладаг дулаан болон цахилгааны хосолмол станц (ДЦС)–тай. Эдгээрээс хамгийн хуучин нь болох ДЦС–2 нь агаарыг хамгийн их бохирдуулдаг ба нэн даруй хаах шаардлагатай хэмээн үзэж байгаа боловч Засгийн газар хотын цахилгаан болон дулааны хэрэгцээ шаардлага хурдацтай өсөн нэмэгдэж буйгаас Улаанбаатар хотын зүүн хэсэгт төлөвлөгдөж буй нэмэлт станц ашиглалтанд орох хүртэл хаах боломжгүй гэж үзсэн. Мөн улсын эдийн засаг өссөнөөр автомашины тоо хэмжээ нэмэгдэж, энэ нь төв суурин газруудын агаарын бохирдолд нөлөөлж байна. Үүнээс гадна Улаанбаатар хот хөндийд байрладаг тул агаарын бохирдол сарнихгүй, төвлөрөх нөхцөл бүрдүүлдэг.

41. Монгол Улсын хууль тогтоомжид автомашин өмчлөгчид, цахилгаан станц болон бусад эх үүсвэрүүдийг өмчлөгчдөд агаар бохирдуулалтын хэмжээгээр төлбөр тооцохоор заасан байдаг. Гэвч төлбөрийн хэмжээг тогтооход шаардлагатай агаарыг бохирдуулагч эх үүсвэрүүдэд тогтмол хяналт тавьдаггүйгээс үүдэн уг төлбөрийг нэхэмжилж чаддаггүй юм.<sup>146</sup> Үүнтэй адил Агаарын тухай хуульд том хэмжээний суурин эх үүсвэрүүдэд хяналт тавьж, хор нөлөөг бууруулах тоног төхөөрөмж суулгахыг шаардаж байгаа боловч хуулиар тогтоосон стандартыг зөрчсөн тохиолдолд ногдуулах торгууль нь бага учраас дээрх төхөөрөмжийг суулгах сэдэл болохгүй байна.<sup>147</sup>

42. Монгол Улсын урт хугацааны хамгийн оновчтой шийдэл нь тодорхой: улс өөрийн сэргээгдэх эрчим хүчний өргөн боломжоо ашиглах алхмыг хурдан хийх шаардлагатай. Тухайлбал, тус улсын өмнөд говь хэсэг нь жилийн 300 өдөр нартай, чийг багатай, хүчтэй салхитай нь салхин болон нарны цахилгаан станц байгуулахад нэн тохиромжтой. Засгийн газар сэргээгдэх эрчим хүчийг 2025 он гэхэд эрчим хүчний үйлдвэрлэлийн 20– 25 хувийг эзлэх хэмжээнд нэмэгдүүлэх зорилт тавьсан боловч энэ хэмжээнд хүрэхэд маш их хүчин чармайлт гаргах хэрэгтэй. 2017 оны байдлаар шинээр суурилуулсан эрчим хүчний эх үүсвэрийн дөнгөж 7 хувь нь сэргээгдэх эх үүсвэрээс гарч байна. 1999– ээс 2010 оны хооронд хийгдсэн нэгэн санаачилгыг тусгайлан дурдах нь зүйтэй: Засгийн газар алслагдсан газруудын 100,000 малчин айлд нарны самбар нийлүүлэх зорилт тавьсан. Энэхүү зорилт нь амжилттай болж, Монголын нийт нүүдэлчин өрхийн 70 хувь нь ногоон эрчим хүчинд холбогдсон гэсэн тооцоо байна. Ерөнхийд нь авч үзвэл 2012 оны Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулиар салхины эрчим хүчээр үүсгэсэн цахилгааныг дэмжих тариф тогтоосон нь 2013 онд ашиглалтанд орсон Монгол Улсын анхны арилжааны салхин станцын төсөл болох Салхит салхин станцыг байгуулахад түлхэц болсон.<sup>148</sup>

43. 2017 оны 3–р сард Монгол Улс 2017–2025 онд Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг баталсан. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь бохирдлыг бууруулах; илүү сайн хариуцлагын тогтолцоо бий болгох; Цэвэр Агаар Санг дахин байгуулах; орчны чанарын хяналт–шинжилгээний чадавхыг бэхжүүлэх; олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд оршино. Энэхүү хөтөлбөр гэр хороололд онцгой анхаарал хандуулсан. Ингэхдээ зөвхөн гэр хороололд илүү олон барилга барихыг дэмжиж, гэрт

<sup>146</sup> ЕЭЗК, Байгаль орчны үзүүлэлтийн тойм: Монгол Улс, 78, 197 дахь тал.

<sup>147</sup> Дээрхтэй адил, 206 дахь тал.

<sup>148</sup> Мэдээж усны төслүүд зэрэг сэргээгдэх эрчим хүчний төслүүд ч мөн адил байгаль орчны болон хүний эрхийн асуудлуудыг үүсгэдэг ба Монгол Улс тэдгээрийн нөлөөнд өртсөн хүмүүсийн эрхийг хүндэтгэн хамгаалах үүргээ биелүүлэх шаардлагатай.

амьдардаг өрхүүдийг орон сууцанд шилжин суурьшихыг дэмжээд зогсохгүй нийслэл хот руу шилжих хөдөлгөөнийг хязгаарлахаар заасан. Тусгай Илтгэгч олон улсын хүний эрхийн эрх зүйд энд харагдахгүй байгаа тодорхой үндэслэлүүдээс бусад тохиолдолд улс доторх хөдөлгөөнийг хязгаарлахыг хориглодог болохыг энд дахин сануулж байна.

44. Агаарын чанарт заналхийлж буй бас нэг зүйл бол тоосжилт, тэр дундаа уул уурхайн үйл ажиллагаа болон хучилтгүй зам дээр тоног төхөөрөмж зөөвөрлөхөд тоосжилтын бохирдол үүсгэдэг уул уурхайн бүсээс гардаг тоосжилт. Агаараар зөөвөрлөгдсөн тоос хол зам туулж, ой мод, ургацыг сүйтгэж, гол, урсгалын чанарт нөлөөлж, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг. Монгол Улсын агаарын бохирдлын тухай хууль тогтоомж нь хот суурин газрын агаарын бохирдолд анхаарал хандуулж, бусад газрууд дахь агаарын бохирдлыг бараг бүр мөсөн орхигдуулсан. Тусгай Илтгэгч уул уурхайн бүс нутгууд дахь агаарын бохирдол, тоос ялгаралтанд хяналт шинжилгээ, зохицуулалтаа нэмэгдүүлж, энэхүү асуудлыг шийдвэрлэхийг уриалж байна.<sup>149</sup>

### **Б. Уул уурхай**

45. Уул уурхай нь хүний эрхэд, ялангуяа ашигт малтмалын нөөцийг олборлосноос гэмтэж, сүйтгэгдсэн экосистемтэй шууд хамааралтай хувь хүн болон бүлгүүдийн эрхэд ноцтой хор нөлөө учруулж болзошгүй. Төр зөвхөн хүний эрх, тэр тусмаа тухайн уул уурхайн үйл ажиллагаатай хамгийн ойр оршин суудаг хүмүүсийн эрхийг хүндэлж, хамгаалдаг уул уурхайн үйл ажиллагааг зөвшөөрөх хэрэгтэй ба хуулийн этгээдүүд тэдгээр эрхийг хүндэтгэх үүрэг хариуцлагаа биелүүлэх нь зүйтэй.

46. Уул уурхай хүний эрхийг дээдэлдэг байхын тулд хамгийн өндөр өртөх магадлалтай хүмүүстэй зөвшилцөж, урьдчилан үнэлгээ хийж, зөвшилцсөний дараа үйл ажиллагаагаа эхлэх ёстой. Тэдгээр хүмүүсийн эрх зөрчигдөж байгаа тохиолдолд эрхийг хамгаалах үр дүнтэй арга хэрэгслүүдийг олж, хэрэглэх ёстой. Зөвхөн байгаль орчинд учруулах хор нөлөөнөөс зайлсхийх, багасгах, боломжит хэмжээнд талбайг сэргээх, нөхөн тэнцвэржүүлсэн тохиолдолд л уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөх нь зүйтэй. Ашигт малтмалын зөвшөөрлүүд нь нийт улсад төдийгүй, уул уурхайн ажиллагаанд хамгийн ихээр шууд өртсөн орон нутгийн бүлгүүдэд ашигтай байх хэрэгтэй. Засгийн газар зөвхөн эдгээр шаардлагууд хангагдсан тохиолдолд уул уурхайн үйл ажиллагаа явуулж байхаар хязгаарлалт тогтоох ёстой ба дүрэм журмуудыг чөлөөт, мэдээлэлтэй олон нийтийн мэтгэлцэх боломжтой ил тод хэлбэрээр хэлэлцэж, баталж, хэрэгжүүлэх ёстой. Хүн бүр дарамт, хорих гэсэн айдасгүйгээр уул уурхайн үйл ажиллагаанд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, эвлэлдэн нэгдэх, тайван жагсаал цуглаан хийх эрхээ хэрэгжүүлэх боломжтой байх ёстой.

47. Уул уурхай нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хөдөлгөгч үндсэн эх үүсвэр нь болсон. Монгол Улс нүүрс, зэс, алт, мөнгө, төмрийн хүдэр, уран зэрэг байгалийн баялаг арвинтай. 2015 онд уул уурхайн салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 16.1 хувь, төсвийн орлогын 19.6 хувь, экспортын орлогын 79.3 хувийг эзэлсэн.<sup>150</sup> 2017 оны 5– р

<sup>149</sup> ЕЭЗК, Байгаль орчны үзүүлэлтийн тойм: Монгол Улс, 27 дахь тал.

<sup>150</sup> НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, “Монгол Улсын уул уурхайн салбар дахь авлигын эрсдэлийн үнэлгээ”, 2016, 15 дахь тал.

сарын байдлаар нийт 2,000 гаруй хайгуулын, 1,500 гаруй ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдсон байгаа нь нийт газар нутгийн 6.2 болон 0.9 хувийг тус тус эзэлсэн байна.<sup>151</sup> Нийт тусгай зөвшөөрөл олгогдсон бүс нутгийн дөнгөж 30 хувийг бодит байдал дээр ашиглаж байгаа ба үлдсэн хэсэг нь үнэ цэнэ багатай, дэд бүтэц хангалтгүй, байгаль орчинд үзүүлэх нөлөө зэрэг олон шалтгаанаар идэвхгүй байгаа гэж Засгийн газар тооцоолж байна.

48. Үүнээс гадна хууль бус уул уурхайн хүрээ өргөжиж байна. Малаа алдсан малчид зэрэг олон Монголчууд гар аргаар, жижиг хэмжээгээр уул уурхай эрхэлж байгаагийн ихэнх хэсэг нь ямар нэгэн тусгай зөвшөөрөлгүй байдаг.<sup>152</sup> Эдгээр үйл ажиллагаануудад хөдөлмөрийн аюултай нөхцөл, ажилчидтай зүй бус харьцах, хүчирхийлэх, зохих сургалтгүйгээр мөнгөн ус, цианид зэрэг аюултай химийн бодис ашиглах явдал гардаг.

49. Хуулийн дагуу болон хуулиас гадуурх уул уурхайн үйл ажиллагаа байгаль орчинд болон Монголчууд, нэн ялангуяа малчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд ноцтой аюул занал учруулж байна. Уул уурхайн үйл ажиллагаа тоосжилт болон бусад төрлийн агаарын бохирдолд хүргэж, усны эх үүсвэрүүдийг ширгээж, бохирдуулдаг. Аллювийн уул уурхайд зориулан газар ухах нь голын байгалийн экосистемийг сүйтгэж, усыг уухад аюултай болгодог. Уул уурхайн хог хаягдлыг гол дотор болон голын ойр орчимд хаях нь урсгал усыг бохирдуулдаг. Уул уурхайн ажиллагаанаас шалтгаалан усны гадаргуу доошлох нь малчдын ашигладаг худгуудыг усгүй болгож, ган гачигт дасан зохицоход илүү хүндрэлтэй болгодог.<sup>153</sup> Малчдын ашиглаж дадсан бэлчээрийг нь эзэлснээс тэдний уламжлалт соёлд дарамт үзүүлэхэд нөлөөлдөг.

50. Тусгай Илтгэгч Налайх болон Заамар суманд айлчлах явцдаа уул уурхайн сөрөг нөлөөллийн зарим хэсэгтэй өөрийн биеэр танилцсан. Тэрээр Налайхт шигүү суурьшилтай газрын хажууд Туул голын сав газарт нүүрс олборлож байгааг харсан. Түүнд байшинд нь гарсан цууралт, гэмтлийг зарим оршин суугчид үзүүлсэн ба тэдгээр оршин суугчид үүний шалтгааныг маш ойрхон газар уул уурхайн ажил явагдаж байгаатай холбон тайлбарлаж байв. Тэрээр Заамар суманд Улаанбаатараас эхэлсэн Туул голын урсгалын дээд хэсэгт алтны уул уурхайн газар ухах байгааг харсан ба малчид болон бусад оршин суугчид түүнд алтны уул уурхайн тэдний бэлчээр болон ундны усанд үзүүлэх сөрөг нөлөөний талаар ярьсан. Аль аль газарт уул уурхайн бүс нутагт хүүхдүүд амархан нэвтрэх боломжтой ба үүний улмаас хүн гэмтэж бэртсэн, нас барсан талаар түүнд ярьж байв.

51. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төр бүх ашигт малтмалын ордын өмчлөгч бөгөөд хайгуул хийх болон ашиглах эрхийг тусгай зөвшөөрлөөр олгодог. Тусгай зөвшөөрлийн тоо өнгөрсөн богино хугацааны дотор өндөр хэмжээнд хүрсэн.<sup>154</sup> Уул

<sup>151</sup> ЕЭЗК, Байгаль орчны үзүүлэлтийн тойм: Монгол Улс, 52 дахь тал. Энэ тоо нь сүүлийн жилүүдээс эрс буурсан тоо юм. 2008 онд хайгуулын тусгай зөвшөөрөл нийт газар нутгийн 30 хувийг эзэлж байсан.

<sup>152</sup> Е/С.12/MNG/CO/4, пара 16.

<sup>153</sup> Засгийн газрын тайлагнаж буйгаар 2014 онд Монголд байгаа 34,000 гаруй худгийн 26,000 орчим нь уул уурхайн үйл ажиллагаанд хамааралтай байна. Монгол Улс, “Үндэсний тав дахь тайлан: Биологийн олон янз байдлын тухай Конвенци”, 11–12 дахь тал. Уур амьсгалын өөрчлөлт, ой устах, усалгаатай хөдөө аж ахуй болон бусад өрсөлдөх газар ашиглах хэлбэрүүд Монгол Улсын усны нөөцөд дарамт үзүүлэхэд нөлөөлдөг. Кэйн, И. болон бусад, Монгол Улс дахь хариуцлагатай уул уурхай: Эерэг оролцоог нэмэгдүүлэх нь (Брисбань, Тогтвортой ашигт малтмалын институты, 2015), 28–29 дэх тал.

<sup>154</sup> 2008–аас 2010 онуудад тусгай зөвшөөрлийн тоо 5,202 (4,111 хайгуулын, 1,091 ашиглалтын)–оос 4,137

уурхай Монгол Улсын байгаль орчин болон соёлд хэт их нөлөө үзүүлж байна гэсэн санаа зовнилын хариуд Улс 2010 онд хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг түр хугацаагаар хориглосон. Энэхүү хоригийг 2014 онд цуцалсан боловч зарим бүс нутагт, тухайлбал тусгай хамгаалалттай газар нутаг эсвэл гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт хамгийн эмзэг усны эх үүсвэрийг хамгаалахаар заасан Урт нэртэй хуульд багтсан бүс нутгуудад уул уурхай явуулахыг хориглосон хэвээр байна. Энэхүү хуулиар усны эх үүсвэр болон ойгоос 200 метрийн дотор орших 200 орчим хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцалсан.<sup>155</sup> Гэсэн хэдий ч олон хамгаалагдсан гэх газруудад уул уурхайн ажил явагдаж байгаа талаар тайланг Тусгай Илтгэгч сонссон.

52. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгохоос өмнө байгаль орчны үнэлгээ, олон нийтийн хэлэлцүүлэг, орон нутгийн бүлгийн зөвшөөрөл авсан байх шаардлагатай. Уул уурхайн ажлыг зөвхөн соёлын өвд хохирол учруулахгүй байлгах үүднээс угсаатан зүй болон археологийн чиглэлээр мэргэшсэн байгууллага судалгаа явуулсны дараа л явуулах ёстой. Мөн уурхайн ажил явуулах хүсэлт гаргаж буй этгээдүүд нь газрыг төрөлх буюу эдийн засгийн хувьд ашиглах боломжтой төлөвт нөхөн сэргээх талаар заасан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг гаргаж өгөх ёстой. Уул уурхайн компаниуд нөхөн сэргээлт хийх үүргээ биелүүлэх явдлыг хангахын тулд уурхай ажиллуулж буй этгээд бүр жилийн байгаль орчныг хамгаалах төсвийнхөө хагасыг тусгай санд барьцаа болгож оруулах шаардлагатай ба энэхүү сангийн ашиглалтыг холбогдох сум, дүүргийн засаг дарга хариуцдаг. 2015 онд уул уурхайн үйл ажиллагаанаас олсон ашиглалтын төлбөрийн хамгийн багадаа гуравны нэг хэсгийг тусгай зөвшөөрөл олгогдсон сум, дүүргийн орон нутгийг хөгжүүлэх санд шилжүүлэхээр зааж Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан.

53. Эдгээр хууль тогтоомжуудаар цаасан дээр хүний эрхийн зөрчил болон байгаль орчинд үзүүлэх хор нөлөөллийг бууруулах арга хэмжээг зааж өгсөн. Гэвч хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нөлөөлөх боломжтой боловч цаг хугацааны хувьд шийдвэр гаргах явцад нөлөөлж чаддаггүй. Мөн үнэлгээ нь төслүүдийн нийгэм болон соёлын өвөд үзүүлэх үр нөлөөнд бараг анхаардаггүй.

54. Үүнтэй нэгэн адил орон нутгийн захиргааны зөвшөөрлийг авах шаардлага нь зарчмын хувьд үр дүнтэй юм шиг боловч бодит байдал дээр амжилттай хэрэгждэггүй. Нэгдүгээрт, хуульд орон нутгийн захиргаа үзэл бодлоо илэрхийлэхэд зөвхөн сар гаруй л хугацаа олгодог нь байгаль орчны үнэлгээг танилцуулж, олон нийтэд мэдээлж, хэлэлцүүлэг хийхэд хангалтгүй хугацаа юм. Хоёрдугаарт, орон нутгийн засаг захиргааны албан хаагчид нь хангалттай мэдээлэл байхгүй, эсвэл ард иргэдийнхээ санаа бодлыг хангалттай харгалзаж үздэггүй байх магадлалтай. Орон нутгийн албан хаагчид өөрсдийн уурхайг хаах эрхээ хууль бус төлбөр хураамж авах хэлбэр болгон ашиглах магадлалтай. Гуравдугаарт, орон нутгийн засаг захиргаа болон уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн хооронд байгуулсан гэрээнүүдийг нийтэд ил тод болгох шаардлага тавигддаггүй. Эцэст

---

(2,979 хайгуулын, 1,158 ашиглалтын) болж буурсан.

<sup>155</sup> ЕЗЗК, Байгаль орчны үзүүлэлтийн тойм: Монгол Улс, 31 дэх тал.



нь, орон нутгийн эрх бүхий албан тушаалтнууд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг эсэргүүцсэн тохиолдолд тэдний саналыг зарим тохиолдолд Засгийн газар хэрэгсэхгүй болгох буюу авч хэлэлцдэггүй.

55. Тусгай Илтгэгч Заамар суманд ажиллах үеэдээ дээрх асуудлуудыг биечлэн харсан болно. Тэрээр 1993 онд эхэлж, тус сумын ойролцоогоор 280,000 га газрын 50,000 гаруй га-г хамарсан 100 гаруй уул уурхайн ажлын тусгай зөвшөөрөл олгосон “Алт-1” хөтөлбөрийн үр дүнд байгуулагдсан алтны уул уурхайнуудтай танилцсан. Нэг бүр нь оффисын барилга шиг том хэмжээтэй экскаваторууд голыг ухаж; хүүхдүүд хамгаалалтгүй, аюултай ил цооногийн дэргэд тоглож; тоосжилтын үүл амьсгалын замын өвчин үүсгэж, худгууд ширгэж, загас харагдахаа больж, малчдын бэлчээр ихээхэн багассан байсан. Нөхөн сэргээхийн оронд Засгийн газар шинэ “Алт-2” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр шийдсэн нь энэхүү суманд илүү олон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход хүргэнэ. Шинэ уурхайнууд үлдсэн бэлчээрийн газрын ихэнх хэсгийг сүйтгэх болно. Орон нутгийн иргэд энэхүү төслийг эсэргүүцсэн боловч үүнийг үл харгалзан Засгийн газар тусгай зөвшөөрөл олгож эхэлсэн байна.

56. Орон нутгийн иргэдийн өмнө хүлээсэн хүний эрхийн үүргүүдээ биелүүлэхийн тулд Засгийн газар Алт-2 саналд бүрэн хэмжээний, стратегийн байгаль орчны үнэлгээг Алт-1 хөтөлбөрийн байгаль орчин болон нийгмийн үр нөлөөг харгалзан үзэж, нэмж тусгай зөвшөөрөл олгохдоо үр нөлөөг сайтар судлах шаардлагатай. Мөн уг үнэлгээг олон нийтэд нээлттэй болгож, Алт-1 хөтөлбөрийн сөрөг үр нөлөөг үр дүнтэйгээр нөхөн сэргээж, нөхөн төлбөр олгох нь зүйтэй. Засгийн газар хангалттай мэдээлэл дээр үндэслэсэн, үр дүнтэй олон нийтийн хэлэлцүүлэг явуулж, Алт-2 үргэлжлэх ёстой эсэх, хэрэв тийм бол хэрхэн үргэлжлэх ёстой эсэх талаар орон нутгийн иргэдийн шийдвэрийг дагах нь зүйтэй.

57. Ерөнхийд нь авч үзвэл Монгол Улсын хууль тогтоомжоор уул уурхайн талбайг нөхөн сэргээх илүү тодорхой шаардлагуудыг тогтоох хэрэгтэй. Талбай нэг бүр хэрэгцээтэй эсэх талаар нарийвчилсан үнэлгээг ихэнх тохиолдолд хийдэггүй ба Тусгай Илтгэгчид уул уурхайн салбарын болон салбарын бус ярилцсан хүмүүс бодит байдал дээр нөхөн сэргээлт хийхдээ зөвхөн нээлттэй цооногийг бөглөдөг эсвэл огт хийдэггүй гэж мэдээлсэн. Нөхөн сэргээлт хийгдээгүй орхисон талбайг магадгүй хууль бусаар гар аргаар алт олборлогчид ашигладаг. Мөн Тусгай Илтгэгчид эскроу дансанд нөхөн сэргээлтийн зориулалтаар хийх шаардлагатай мөнгийг шилжүүлдэггүй, эсвэл бусад зорилгоор зарцуулдаг гэсэн мэдээлэл өгсөн. Үүнээс гадна нөхөн сэргээлтийн компаниудын туршлага, өрсөлдөж байгаа байдал нь мөн санаа зовоосон асуудал: тодруулбал нөхөн сэргээлтийн тусгай зөвшөөрөлтэй ойролцоогоор 400 компаниас бодит байдал дээр цөөн тооны компани нь үйл ажиллагаа явуулдаг ба зарим нөхөн сэргээлтийн компаниуд нөхөн сэргээлт гэсэн нэрийн доор олборлолтоо үргэлжлүүлэн явуулдаг гэсэн мэдээлэл байна.

58. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд гардаг зарим асуудлууд нь хангалттай хөрөнгө байхгүйгээс шалтгаалсан байдаг. Тухайлбал, Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар хангалттай хэмжээнд уул уурхайн үйл ажиллагааг шалгах хангалттай техникийн нөөц, чадавхгүй гэдгийг Тусгай Илтгэгч сонссон.<sup>156</sup> Тусгай Илтгэгч Налайх дахь нүүрсний

<sup>156</sup> ЕЭЗК, Байгаль орчны үзүүлэлтийн тойм: Монгол Улс, 65 дахь тал.

уурхайн талбайнууд дээр очиход оршин суудаг айлуудын дэргэд илт хууль бус уул уурхай явагдаж буй талбайнуудыг түүнд харуулсан. Тус газрын байшингууд нь газар доорх уул уурхайгаас шалтгаалсан байж болзошгүй гэмтлүүдтэй байв. Тэдгээр иргэд Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газраас тусламж гуйж, бусад төрийн байгууллагуудад гомдол гаргах оролдлого хийсэн боловч оршин суугчдад ямар нэгэн арга зам олгогдоогүй мэт байв.

59. Авлига уур уурхайг зохицуулсан хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд томоохон хүндрэл учруулдаг гэсэн тайлбарыг Тусгай Илтгэгч олон удаа сонссон. 2015 онд Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн зөвлөл шүүх, нийтийн алба (E/C.12/MNG/CO/4, пара. 11–г харна уу)–ыг хамааруулан тус улсад авлига давамгайлсан талаар санаа зовнилоо илэрхийлсэн. Тус Зөвлөл Монгол Улсыг авлигын эсрэг үл хүлцэх бодлого хэрэгжүүлэх, шүүгч, прокурор, цагдаа нарт хуулийн хэрэгжилтийг хангахад хүлээх үүрэг хариуцлагыг таниулах зэргээр авлигын эсрэг хүчин чармайлтаа хоёр дахин нэмэгдүүлэхийг уриалсан. Тус зөвлөл Монгол Улс авлигын эсрэг үйл ажиллагаанд оролцогчид, ялангуяа хохирогчид, мэдээлэгчид, гэрчүүд, тэдгээрийн хуульчдын хүний эрхийг хамгаалах хэрэгтэй болохыг дурдсан.

60. Мөн тус Зөвлөл уул уурхайн төслүүдийн малчдын хүний эрхэд үзүүлэх сөрөг нөлөөний талаар санаа зовниж буйгаа илэрхийлсэн (мөн тэнд, пара 8).<sup>157</sup> Тодруулбал, малчид ашиглаж дадсан газар нутагт Засгийн газар ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход малчдын чөлөөт, урьдчилсан, мэдээлэлтэй зөвшөөрлийг авдаггүй ба уул уурхайн төслүүд сөрөг үр нөлөө үзүүлсэн малчдад зохих нөхөн төлбөрийг олгодоггүй талаар санаа зовнисноо илэрхийлсэн (пара 8). Зөвлөл Монгол Улсад дараах зөвлөмжүүдийг өгсөн: (а) ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгохоосоо өмнө хүний эрхийн болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх; (б) үнэлгээний үйл явцад тухайн төслүүд нөлөөлж болох бүхий л сонирхогч этгээдүүдийн идэвхтэй оролцоог хангах; (в) малчдын эрхэд нөлөөлж болох ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгохоос өмнө тэдэнтэй өргөн хүрээний хэлэлцүүлэг зохион байгуулах; (г) малчдад хүртээмжтэй, зардал багатай, үр дүнтэй гомдол гаргах механизмыг бий болгох; (д) тэдэнд зохих нөхөн төлбөр олгох явдлыг хангах (пара 8–9).

61. Үүнтэй холбогдуулан, малчин иргэд болон уурхайн ажиллагаа эрхлэгч нарын хооронд үүссэн маргааныг амжилттай шийдвэрлэсэн жишээ бол Говь цөлийн малчид болон дэлхийн хамгийн том зэсийн уурхайнуудын нэг болон Оюу Толгой уурхайн хооронд үүссэн зөрчлийг шийдвэрлэсэн явдал юм. 2012 онд малчид Олон Улсын Санхүүгийн Корпорацийн Нийцлийн зөвлөх/Омбудсмэнд уул уурхайн үйл ажиллагаа тэдгээрийн амьжиргаа, эрүүл мэнд, соёлыг сүйтгэж байгаа хэмээн гомдол гаргасан. Малчид болон уул уурхай эрхлэгч Омбудсмэний эвлэрүүлэн зуучилсны дагуу малчид, Оюу Толгой, Засгийн газрын төлөөллөөс бүрдсэн гурван талт зөвлөл байгуулахаар тохиролцсон ба гомдол болон ирээдүйн аливаа асуудлуудыг шийдвэрлэх, хараат бус, бие даасан арга хэрэгсэл болсон. Тэд уул уурхайн компанийн зүгээс шинэ худаг барих, үйл ажиллагааны үр нөлөөнд тавих хяналт шинжилгээг сайжруулах (малчдын оролцоонд суурилсан хяналт

<sup>157</sup> Мөн Хүүхдийн эрхийн Зөвлөл (CRC/C/MNG/CO/5) болон хүний эрх, үндэстэн дамнасан корпорациуд болон бусад бизнесийн байгууллагуудын асуудлаарх Ажлын хэсэг үүнтэй төсөөтэй санаа зовнил илэрхийлсэнтэй танилцана уу (A/HRC/23/32/Add.1).

шинжилгээ зэрэг), нутгийн иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах зэрэг үүрэг амлалтыг багтаасан тохиролцоонд хүрсэн.<sup>158</sup> Энэхүү үйл явдал нь уул уурхайн компаниуд хүний эрхийг хүндэтгэх үүрэг хариуцлагаа биелүүлэхийн тулд малчидтай хэрхэн зөвшилцөж болохыг харуулсан жишээ юм.<sup>159</sup>

### **В. Байгаль хамгаалалт ба тусгай хамгаалалттай газрууд**

62. Хүний эрхийг бүрэн эдлэх нь эрүүл экосистемээс хамааралтай байдаг бол эрүүл экосистем нь эргээд биологийн олон янз байдлаас хамааралтай (А/НRC/34/49, пара. 9–21–г үзнэ үү). Монголын соёл урт удаан хугацааны турш байгалийн орчинд дархан цаазат газруудыг хамгаалахын ач холбогдлыг хүлээн зөвшөөрсөөр ирсэн. 13–р зуунд Чингис Хаан дөрвөн уулыг дархан цаазат болгосон ба үүнийг нэг болох Бурхан Халдан Уулыг түүний төрсөн газар бөгөөд түүний бунхан байгаа газар хэмээн үздэг. 18–р зууны эхээр “Халх Журам” хуулийн дагуу 16 уулыг ан хийх болон мод бэлтгэл хийхээс хамгаалсан. 1778 онд Улаанбаатар хотын өмнө хэсэгт байрлах Богд Хан Уулыг тусгай хамгаалалттай газар болгосон. Богд Хан нь дэлхийн хамгийн анхны дархан цаазат газар хэмээн тооцогддог.

63. 1992 оны Нэгдсэн Үндэстний Байгууллагын Байгаль орчин, хөгжлийн Чуулга уулзалтаас хойш Монгол Улс хамгаалалттай бүс нутгийг өргөжүүлсэн. Энэхүү үндэстний системд одоогоор тус улсын газар нутгийн 7.9 хувийг эзэлсэн 20 тусгай хамгаалалттай газар болон 7.6 хувийг эзэлсэн 32 дархан цаазат газар багтана. Мөн Монгол Улс 36 газрыг байгалийн нөөц газар (газар нутгийн 2.3 хувь), 14 дурсгалт газар (0.9 хувь) болгон тогтоосон. Иймд Монгол Улс Биологийн олон янз байдлын тухай конвенцийн талууд тогтоосон улс бүр газар нутгийнхаа хамгийн багадаа 17 хувийг 2020 он гэхэд тусгай хамгаалалттай газар болгон тогтоох зорилгод аль хэдийн хүрсэн. Монгол Улсын хууль тогтоомжоор мөн орон нутгийн хамгаалалттай бүс нутаг тогтоох эрхийг олгосон ба энэ нь тус орны газар нутгийн 12 хувийг эзэлдэг. Мөн Засгийн газар 2030 он гэхэд тусгай хамгаалалттай газар нутгийг нийт газар нутгийн 30 хувийг эзэлж байх зорилгыг өмнөө тавьсан.

64. Хамгаалалттай газар нутгууд нь ховордсон болон ховордож болзошгүй цасны ирвэс, хулан, халиун буга, хүдэр, аргаль, Альпийн зэрлэг ямаа зэрэг төрөл зүйлийн амьтдын амьдрах нутгийг хадгалахад чухал нөлөө үзүүлдэг. Байгалийн унаган төрхийг хадгалахыг идэвхтэй дэмжигчид болон ойн цагдаа нарын шаргуу хөдөлмөр, нутгийн иргэдийн дэмжлэгээр хамгаалалттай газрууд нь төрөл зүйлүүдийн тоо толгойг хадгалах, цаашлаад нэмэгдүүлэх боломжийг бий болгодог. Тухайлбал, Түргэний болон Цагаан Шувуутын тусгай хамгаалалттай газрын цасны ирвэсийн тоо олон жил буурсны эцэст сүүлийн жилүүдэд аажмаар нэмэгдсэн. Монгол Улс дахь хамгийн алдартай байгалийн унаган төрхийг хадгалсан түүх нь магадгүй сүүлчийн жинхэнэ зэрлэг адуу болох тахь

<sup>158</sup> Эдгээр гэрээнүүд [www.accountabilitycounsel.org/wp-content/uploads/2017/08/Complaint-Resolution-Agreement-1\\_ENG.pdf](http://www.accountabilitycounsel.org/wp-content/uploads/2017/08/Complaint-Resolution-Agreement-1_ENG.pdf); болон [www.accountabilitycounsel.org/wp-content/uploads/2017/08/Complaint-Resolution-Agreement-2\\_ENG.pdf](http://www.accountabilitycounsel.org/wp-content/uploads/2017/08/Complaint-Resolution-Agreement-2_ENG.pdf). гэсэн хаягуудад нээлттэй.

<sup>159</sup> Софи Эдвардс, “Монголын хэсэг малчид хэрхэн уул уурхайн том компанийг буулган авч, ялсан талаар”, 2017 оны 8–р сарын 9. [www.devex.com/news/how-a-group-of-mongolian-herders-took-on-a-mining-giant-and-won-90765](http://www.devex.com/news/how-a-group-of-mongolian-herders-took-on-a-mining-giant-and-won-90765).

буюу Пржевальскийн адуу юм. Тоо толгой нь 40–өөс бага болж, 1960–аад онд устаад байсны дараа дэлхий нийтийн байгалийн унаган төрхийг хадгалахыг идэвхтэй дэмжигчид тэднийг сэргээхийн төлөө ажилласан. Тэднийг 1990–ээд онд Монголын гурван газрыг хамруулсан зэрлэг байгальд дахин нутагшуулсан. Хустайн дархан цаазат газарт байрлах хамгийн том сүрэг нь одоогоор 300 гаруй нас бие гүйцсэн тахьтай.<sup>160</sup>

65. Монголчууд өөрсдийн байгалийн орчинг хүндэтгэх, унаган төрхийг нь хадгалах урт хугацааны түүхээрээ бахархах хэрэгтэй. Гэсэн хэдий ч өнөөдөр тус улсын экологийн дөрвөн бүс нутаг бүрт бэлчээрийн даац хэтрэх, уур амьсгалын өөрчлөлт, уул уурхайн үйл ажиллагаа, хөдөө аж ахуй, хот суурин газар өргөжин тэлснээс шалтгаалсан дарамт нэмэгдэж байна. Эдгээр өсөн нэмэгдэж буй дарамтын нэг илрэл бол малчдын Улаанбаатар болон бусад төв суурин газар руу шилжин суурьших хөдөлгөөн юм. Бас нэгэн илрэл нь цасны ирвэс, хавтгай зэрэг төрөл зүйлийн амьтад ховордсон хэвээр байгаа, мазаалай, халиун буга зэрэг зарим амьтад нэн ховордсон явдал юм. Мөн соргог бөхөн, халиун буга зэрэг олон төрөл зүйлүүдийн тоо толгой сүүлийн жилүүдэд цөөрсөн.<sup>161</sup>

66. Зарим экосистемүүдийн хамгаалалттай бүс нутагт хамрагдах ёстой бүх газрууд хамрагдаагүй байдаг.<sup>162</sup> Монгол Улс биологийн олон янз байдлыг хамгаалах системчлэгдсэн мэдээллээр дутмаг. Ерөнхийд нь авч үзвэл, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар тусгай хамгаалалттай газарт тооцох шалгууруудыг тогтоогоогүй, мөн менежментийн төлөвлөгөө хөгжүүлэх, хэрэгжүүлэхийг шаардаагүй.<sup>163</sup> Иргэний нийгмийн байгууллагууд болон орон нутгийн бүлгүүд зарим хамгаалалттай газруудыг хамтран удирдах талаар сонирхолтой санаачилгууд байдаг боловч нийгмийн бүлэгт суурилсан удирдлагын хууль зүйн тогтолцоо хараахан байхгүй байна. Үүнээс гадна мөн л хэрэгжүүлэхэд асуудлууд бий. Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ нь үр дүнтэй хяналт шинжилгээ, шалгалт хийх хангалттай нөөц байхгүй талаар Тусгай Илтгэгч сонссон.

67. Байгалийн унаган төрхийг хадгалах нь үндэсний тэргүүлэх чиглэл бөгөөд энэ нь чухал боловч төр бусад салбаруудын нэгэн адил байгалийн унаган төрхийг хадгалах арга хэмжээнүүдийг баталж, хэрэгжүүлэхдээ хүний эрхийн үүргээ дагаж мөрдөх ёстой. Тухайлбал, ойд ан хийх болон бусад байдлаар ашиглахад хязгаарлалт тавихдаа зөвхөн орон нутгийн нийгмийн бүлгүүд, ялангуяа урт удаан хугацааны турш эдгээр хэрэглээнд материаллаг болон соёлын оршин тогтнол нь суурилж ирсэн нийгмийн бүлгүүдтэй зөвшилцсөний үндсэн дээр хийх ёстой. Тодруулбал, Монгол орны хойд хэсэг, ОХУ–ын хилийн орчмын ойн Тэнгис Шишгэдийн тусгай хамгаалалттай газар ан хийхийг хязгаарласантай холбоотой гомдлуудыг сонссон. Цаа буга маллаж, уламжлалт амьдрал нь ойд суурилдаг үндэстний цөөнх Духа буюу Цаатан үндэстэнд хууль бус ан хийхийн эсрэг хууль чанд үйлчилж байна.<sup>164</sup> Засгийн газар хамгаалалттай бүс нутгийн

<sup>160</sup> Пэйж Виллиамс, “Пржевальскийн адуу гайхалтайгаар буцан ирсэн нь”, *Smithsonian Magazine*, 2016 оны 12–р сар.

<sup>161</sup> ЕЭЗК, Байгаль орчны үзүүлэлтийн тойм: Монгол Улс, 260 дахь тал.

<sup>162</sup> Байгалийн төлөөх Дэлхий нийтийн сан, Монгол Улс дахь Хөтөлбөрийн Оффис, Монгол Улс дахь биологийн олон янз байдлыг хамгаалахын тулд хийдлийг нөхөх нь, 2010 оны 8–р сар.

<sup>163</sup> ЕЭЗК, Байгаль орчны үзүүлэлтийн тойм: Монгол Улс, 274 дэх тал.

<sup>164</sup> Марине Гаутхиэр, Риккардо Правэттони, “Бидэнд цаа буганаас өөр юу ч байхгүй”: байгалийн унаган байдлыг хамгаалах асуудал Монголын Духаг сөнөх аюул заналхийлж байна”, *Guardian*, 2016 оны 8–р сарын 26.

удирдлаганд оролцуулах арга замыг олох, ан хийх болон байгалийн экосистемийг бусад байдлаар ашиглах нь тэднийг соёл, уламжлалаа хадгалахад саад болохгүй байлгах үүднээс тэдэнтэй болон тэдэнтэй ижил байр сууьтай иргэдтэй зөвшилцөх нь зүйтэй.

68. Тусгай Илтгэгч Засгийн газар хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжоо шинэчлэх талаар хэлэлцэх гэж байгаа гэж ойлгосон. Энэ нь тусгай хамгаалалттай газар нутгийг тогтоох, удирдахад илүү тодорхой удирдамж өгөх, хяналт шинжилгээ хийж, хэрэгжүүлэх нөөцийг нэмэгдүүлэх, нутгийн бүлгүүдийг хамгаалалттай бүс нутгуудын хяналт шинжилгээ, хамгаалалтанд оролцуулах зэргээр хууль тогтоомжийг сайжруулах таатай боломж юм.

### **Г. Мэдээлэл олж авах, олон нийтийн оролцоо болон эдгээр эрхийг олж авах арга барил**

69. Байгаль орчны талаарх мэдээлэл олж авах, байгаль орчны шийдвэр гаргахад олон нийтийн оролцоог хангах, эдгээр эрхийг тогтоох арга хэрэгслүүдтэй байх нийгмийн гишүүд байгаль орчны асуудлуудыг ойлгох байгаль орчинд нөлөөтэй шийдвэрт мэдээлэл дээр суурилсан хувь нэмэр оруулах, хүний эрх болон дотоодын байгаль орчны стандартууд хэрэгжилтийг хангах үүднээс шүүх болон бусад хяналтын байгууллагуудад хандах зэрэг боломжүүдийг нээхэд чухал юм.

#### **1. Мэдээлэл олж авах эрх**

70. Хүн бүрийн мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрхэд байгаль орчны талаар мэдээлэл олж авах нь ч мөн хамаарна (A/HRC/37/59, хавсралт, тогтолцооны зарчим 7). Байгаль орчны мэдээлэлд олон нийтийн оролцоог хангах нь хувь хүмүүст байгаль орчинд учруулсан хор нөлөө нь тэдний амьд явах, эрүүл байх зэрэг эрхүүдийг хэрхэн доройтуулдаг болохыг ойлгох боломжтой болгодог. Мэдээлэл олж авах эрх нь тэдний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, оролцох, эрхээ сэргээлгэх зэрэг бусад эрхээ эдлэхэд дэмжлэг үзүүлдэг. Төр байгаль орчны талаарх мэдээллийг тогтмол цуглуулж, шинэчилж, тарааж, мөн аливаа хүн эсвэл байгууллагын хүсэлтээр, ямар нэгэн хууль зүйн буюу бусад сонирхол үзүүлэх шаардлагагүйгээр төрийн эрх бүхий байгууллагуудад байгаа байгаль орчны талаар мэдээллийг бага зардлаар, үр дүнтэйгээр, хурдан хугацаанд авах боломжтой байлгах хэрэгтэй.

71. Монгол Улсад байгаль орчны талаар мэдээлэл авах гол онлайн талбар нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны ажиллуулдаг Байгаль орчны Мэдээллийн Төв ([www.eic.mn](http://www.eic.mn)) юм. Тус яам мөн өөрийн үйл ажиллагааны талаар мэдээллийг өөрийн цахим хуудсандаа байршуулдаг ([www.mne.mn](http://www.mne.mn)). Энэхүү хоёр цахим хуудсан дээрх мэдээллүүд нь хоорондоо зарим тохиолдолд нийцдэггүй, мөн зарим мэдээлэл нэг цахим хуудсан дээр нь байгаа мөртлөө нөгөө цахим хуудсан дээр байхгүй байдаг бөгөөд үүний шалтгаан нь тодорхой бус байдаг. Бусад яамд өөрсдийн ажлын талаар мэдээллийг нээлттэй болгохдоо тус яам шиг идэвхтэй байдаггүй. 2011 оны Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулиар мэдээлэл хүсэх журмыг заасан. Ерөнхийдөө тус хуулиар мэдээлэл авах олон нийтийн хүсэлтэд ажлын долоон өдрийн дотор хариу өгөхийг шаарддаг ба энэхүү хугацааг дахин ажлын долоон өдрөөр сунгаж болно.

72. Бодит байдал дээр мэдээллийн хүртээмжтэй байдал ихээхэн ялгаатай байдаг. Эерэг талаас нь авч үзвэл нийслэлийн агаарын чанарын талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал нь сайн явдал юм. Тухайлбал, хотын захиргааны байгууллагууд хот даяар гадаа байршсан дэлгэцэн дээр агаарын чанарын талаар мэдээллийг харуулдаг, тэд мөн энэхүү мэдээллийг интернет болон утасны аппликэйшнээр дамжуулан өргөн хүрээнд нээлттэй болгосон.<sup>165</sup> Гэвч бусад хотууд, суурийн газруудын хувьд мэдээлэл ил тод байдаггүй, гол бохирдуулагчдын ялгаруулж буй бохирдлын тодорхой хяналт байдаггүй. Бүр нийслэл хотод ч гэр хорооллын агаарын чанарын тогтвортой, автомат хяналт сул байгаа учир оршин суугчдын ялгаруулсан агаарын бохирдлыг хянаж чадахгүй байна.<sup>166</sup>

73. Усны чанар, уул уурхайн үйл ажиллагаа, тоосжилтоос үүдсэн бохирдол зэрэг бусад байгаль орчны асуудалтай холбоотой мэдээллийн нээлттэй байдал бүүр хомс байна. Дэлхийн Нөөцийн Институтийн сүүлийн үед хийсэн судалгаагаар нэн ялангуяа усны чанарын талаар мэдээлэл нээлттэй биш хэмээн дүгнэсэн ба энэхүү мэдээллийг Засгийн газраас хүссэн хүсэлтүүдэд хариу өгөөгүй байна.<sup>167</sup> Хувийн байгууламжийн ялгаруулалт, ялгаруулалтыг зохицуулсан зөвшөөрөл, тодорхой компаниудын нийцтэй байдлын талаар нийтэд нээлттэй мэдээлэл байхгүй бололтой. Том аж үйлдвэрүүдэд байгууламжийн түвшинд зөвшөөрлийн мэдээлэл зэрэг ялгаруулалтын талаар мэдээллийг гаргахыг ямар ч төрийн байгууллага шаарддаггүй. Усыг бохирдуулж буй аж үйлдвэрүүдийн эзэмшлийн мэдээлэл, байршил, нэр нь ил тод байдаггүй.<sup>168</sup> Үүнтэй нэгэн адил албадан хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл авахад хэцүү эсвэл бүр боломжгүй байдаг. Байгаль орчны тусгай зөвшөөрөл олгох ажиллагааны нэг хэсэг болох байгаль орчны менежментийн төлөвлөгөө ихэнхдээ хаалттай байдаг.<sup>169</sup>

## 2. Олон нийтийн оролцоо

74. Хүн бүрийн өөрсдийн засгийн газар болон олон нийтийн асуудлуудад оролцох эрхэд байгаль орчны талаар шийдвэр гаргах ажиллагаанд оролцох оролцоо багтана (А/НRC/37/59, хавсралт, тогтолцооны зарчим 9). Олон нийтийн оролцоо нь үр дүнтэй байхын тулд нөлөөнд өртөж болох олон нийтийн бүх гишүүдэд нээлттэй байж, шийдвэр гаргах ажиллагааны эрт үе шатанд явагдах ёстой.

75. Тусгай Илтгэгчийн айлчлалынхаа үеэр уулзсан иргэний нийгмийн төлөөллүүдийн хичээл зүтгэл, мэдлэг, эрч хүч нь түүнд их таалагдсан. Гэвч Тусгай Илтгэгч иргэний нийгмээс байгаль орчны шийдвэр гаргах ажиллагаанд оролцох нь бэрхшээлтэй байдаг талаар олон гомдол сонссон. Тухайлбал, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний журамд олон нийтийн оролцоог хангахаар заасан боловч олон нийттэй зөвшилцөхөд дөнгөж 30 хоног өгдөг. Энэ нь хэлэлцүүлэг зохион байгуулах, ялангуяа тухайн төсөл нь том газар нутагт тархан суурьшсан, улмаар хүрэхэд хүндрэлтэй малчдад нөлөөлөх тохиолдолд хангалттай хугацаа биш юм. Мөн үр дүнтэй, оролцоог хангасан зөвшилцөх

<sup>165</sup> Зөвхөн Монгол хэл дээр, [www.tsag-agaar.gov.mn/](http://www.tsag-agaar.gov.mn/).

<sup>166</sup> ЕЗЗК, Байгаль орчны үзүүлэлтийн тойм: Монгол Улс, 205 дахь тал.

<sup>167</sup> Дэлхийн Нөөцийн Институти, “Шударга ёсоор цангах нь: Ил тод байдал ба Индонези, Монгол, Тайланд улсууд дахь цэвэр усны төлөөх ядуусын тэмцэл”, 2017, 42, 43, 50 дахь тал.

<sup>168</sup> Дээрхтэй адил, 42 дахь тал.

<sup>169</sup> ЕЗЗК, Байгаль орчны үзүүлэлтийн тойм: Монгол Улс, 64 дэх тал.

ажиллагаа явуулахад төрийн байгууллагууд болон бизнесийн байгууллагуудын чадавх ихэнхдээ дутмаг байдаг байна. Үүний улмаас эдгээр төслүүдийн зөвшилцөх ажиллагаа нь үр өгөөжгүй байдаг гэсэн ойлголт түгээмэл байдаг.

### **3. Эрхээ олж авах арга хэрэгслүүдийн нээлттэй байдал**

76. Төрийн хүний эрхийг зөрчсөн тохиолдолд хүний эрхийг сэргээх арга хэрэгслээр үүрэгт байгаль орчинтой холбоотой эрхийн зөрчил мөн багтдаг юм (А/НRC/37/59, хавсралт, 10 дугаар зүйл). Энгийн шаардлага хангасан шүүхийн болон захиргааны хянан шийдвэрлэх ажиллагаа хувь хүмүүст нээлттэй байх явдлыг төр хангах үүрэгтэй. Эдгээр ажиллагаанууд нь дараах шаардлагуудыг хангасан байх ёстой: (а) ялгаваргүй, хараат бус, зардал багатай, ил тод, шударга, (б) нэхэмжлэлүүдийг түргэн хугацаанд шуурхай хянадаг, (в) шаардлагатай туршлага, нөөцтэй, (г) дээд шатны байгууллагад давж заалдах эрхийг хангасан, (д) түр арга хэмжээнүүд, нөхөн төлбөр, эрх сэргээх зэрэг асуудлаар заавал биелүүлэх шийдвэр гаргадаг. Төр олон нийтэд эдгээр ажиллагаануудыг хэрхэн авах талаар зааварчилгаа өгч, авахад гарч болох хэл, бичиг үсэг мэдэхгүй байдал, зардал эсвэл орон зайг туулах зэрэгт холбоотой хүндрэл, саад бэрхшээлүүдийг давж гарахад туслалцаа үзүүлэх нь зүйтэй.

77. Монгол Улсад нийгмийн гишүүн болон иргэний нийгмийн байгууллагууд нь зарчмын хувьд байгаль орчны шийдвэрүүдийн хуульд нийцсэн байдлыг давж заалдах эрхтэй. Гэсэн хэдий ч практикт байгаль орчны нэхэмжлэл гаргахад ноцтой саад бэрхшээлүүд тулгардаг. Хамгийн ноцтой нь хуулиар улсын тэмдэгтийн хураамж төлөхийг шаарддаг нь нэхэмжлэл гаргах боломж олгоход хэтэрхий өндөр үнэтэй байдаг байна. 2016 оны Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулинд нэхэмжлэгч нь олон нийтийн ашиг сонирхлыг төлөөлж байгаа тохиолдолд зардлаас чөлөөлөхөөр заасан. Гэсэн хэдий ч хөрөнгийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан хэрэгжиж эхлээгүй бололтой.<sup>170</sup> Мөн байгаль орчны нийгмийн бүлгүүдийн дунд шүүхүүд шаардлагатай техникийн туршлагагүй бөгөөд шүүхэд хүчтэй дарамт (үүнд, авлигыг хамааруулан гэх) үзүүлэх боломжтой уул уурхайн ашиг сонирхлын эсрэг байгаль орчны байгууллагуудын гаргасан нэхэмжлэл дээр олон нийтэд энэрэнгүй хандахгүй байж магадгүй гэсэн өргөн тархсан санаа зовнил байдаг.

### **Д. Байгаль хамгаалагчдын эрх, аюулгүй байдлыг хангах**

78. Хүний эрхийг хамгаалагчдад байгаль орчинтой холбоотой хүний эрхийг хамгаалж, сурталчлахын төлөө зүтгэдэг хувь хүн, бүлгүүд хамаарна (А/71/281, пара. 7). Хүний эрхийг эдлэх явдал нь хамааралтай байдаг байгаль орчныг хамгаалахын төлөө ажилладаг хүмүүс ч өөрсдийгөө хүний эрхийг хамгаалагч хэмээн тодорхойлдог эсэхээс үл хамааран мөн адил хүний эрхийг хамгаалж, сурталчилж байдаг. Тэд хамгийн их эрсдэлд байдаг хүний эрхийг хамгаалагчдын нэг бөгөөд дэлхийн хаа нэгтээ дунджаар долоо хоног тутам нэг байгаль орчны болон газар хамгаалагчид амиа алддаг. Улс орнууд байгаль хамгаалагчдад сүрдүүлэг, дарамт, айдас, хүчирхийлэлгүйгээр чөлөөтэй үйл ажиллагаа

---

<sup>170</sup> Дээрхтэй адил, 125 дахь тал.

явуулах аюулгүй, боломжийг олгосон орчинг бүрдүүлэх ёстой. Улс орнууд юуны түрүүнд аюулгүй байдал, хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудад зохих сургалт явуулж, сүрдүүлэг, зөрчлийг түргэн хугацаанд, шударгаар мөрдөн шалгаж, гэм буруутай этгээдийг шүүх явдлыг хангах ёстой (А/71/281, бүлэг. V–VI, А/НRC/25/55, пара. 54–133–г үзнэ үү).

79. Хэдийгээр Монгол Улсад бусад зарим улсуудад байдаг хэмжээнд байгаль орчныг хамгаалагчдын эсрэг сүрдүүлэг, түрэмгийлэл тохиолдоогүй хэдий ч Тусгай Илтгэгч айлчлалынхаа явцад зарим байгаль орчин хамгаалагчдаас, ялангуяа хууль бус уул уурхай эсвэл хууль бус ан хийхийг эсэргүүцэхийг оролдох үедээ сүрдүүлэгт өртөж байсан эсвэл түрэмгийлэлд өртөж байсан гэдгийг сонсоход цочирдмоор байсан. Тэрээр алслагдсан бүс нутгуудад үйл ажиллагаа явуулдаг эсвэл эмзэг асуудлуудыг хөнддөг хамгаалагчид илүү өндөр эрсдэлтэй байдалд байдаг болох талаар хэд хэдэн мэдээлэл сонссон.

80. Хамгийн ноцтой хэрэг бол 2015 оны 11–р сарын 11–нд Хөвсгөл Нуурнаас цогцос нь олдсон Төмөрсүхийн Лхагвасүмбэрэл буюу Сүмбээгийн үхэл юм. Нас барахаас нь өмнө хоёр жилийн хугацаанд түүнийг дор хаяж гурван удаа Монголын Цасны Ирвэсийг Хамгаалах Сангийн Говийн Алтайн нурууны Тост ууланд тусгай хамгаалалттай газрын хууль хэрэгжүүлэх ажилтай нь холбоотойгоор ямар нэгэн байдлаар сүрдүүлсэн байдаг. Гэвч үүнийг үл харгалзан цагдаа нар түүний үхлийн шалтгааныг живж, амиа хорлосон хэмээн дүгнэсэн.<sup>171</sup> Энэ бол дэлхий даяарх байгаль орчны төлөө тэмцэгчдийн зуурдын үхлийн нэгэн жишээ: сүрдүүлэг, үүний дараа хүчирхийлэл, дараа нь аллага. Олон хүмүүс энэ залуу байгаль хамгаалагчийн үхлийн шалтгааны албан ёсны дүгнэлтэнд сэтгэл дундуур байгаа. Ийм хангалтгүй мөрдөн байцаалтыг явуулж, ял шийтгэлгүй үлдэх магадлалаас сэргийлэхийн тулд Засгийн газар түүний үхлийг өөрөө мөрдөн байцаах хэрэгтэй. Мөн уг байгаль хамгаалах байгууллагын бусад гишүүдийн аюулгүй байдлыг хангах алхмуудыг хийх шаардлагатай.

81. Тусгай Илтгэгч мөн байгаль орчин хамгаалагчид, сэтгүүлчид, болон бусад уул уурхайн үйл ажиллагааг шүүмжлэгчдийн үгийг хязгаарлахийн тулд хүний нэр төрт халдах хууль тогтоомжийг ашигладаг талаар сонссон. Эрүүгийн хуулиас ерөнхий хүний нэр төрд халдах зүйл заалтыг хассан хэдий ч эрүүгийн хуульд үлдсэн хүний нэр төрд халдах заалтуудын талаар Хүний Эрхийн Хорооны илэрхийлсэн санаа зовнил болон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хэрэгжүүлэхийг зүй бусаар хязгаарлах нөлөө бүхий иргэний хуулийн хүний нэр төрд халдах зүйл заалтуудыг ашиглах явдал нэмэгдсэн талаар мэдээллүүд ирснийг энд дахин давтаж байна.<sup>172</sup>

82. Хүний Эрхийн Үндэсний Комисс хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалж, хөхиүлэн дэмжих хуулийн төслийг боловсруулсан нь Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хороогоор хянагдаж байна. Энэхүү хуулийг батлах нь тус Улсын нэн тэргүүний зорилго байх ёстой.

<sup>171</sup> [www.justice4sumbee.weebly.com/uploads/6/6/4/8/66489409/sumbee\\_letter.pdf](http://www.justice4sumbee.weebly.com/uploads/6/6/4/8/66489409/sumbee_letter.pdf).

<sup>172</sup> CCPR/C/MNG/CO/6, пара. 37.



## V. Дүгнэлт, зөвлөмж

83. Улаанбаатар Туул голыг даван өргөжиж байгаагийн хирээр урт хугацаанд Монгол Улсын хамгаалалттай бүс нутгуудын нэг үнэт зүйл болсон Богд Хан уул руу халдаж байгаа нь Монгол Улсад тулгарч буй бэрхшээлүүдийн илрэл юм. Монгол Улс өөрийн соёлын өвөө хадгалж үлдэхийн тулд хүнд шийдвэрүүдийг гаргаж, эдийн засгаа тэлэх зарим саналуудаас татгалзах шаардлагатай. Тус улс зохих хөрөнгийг байгаль орчноо бодит байдал дээр хамгаалахад зориулах шаардлагатай. Дараах хэсгүүдэд энэхүү тайланд дурдсан салбаруудтай холбоотой зарим гол зөвлөмжүүдийг онцолж байна.

84. Агаарын бохирдолтой холбоотойгоор Тусгай Илтгэгч дараах зөвлөмжүүдийг өгч байна. Үүнд:

- (а) Өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн туршлага, арга барилаас хамгийн үр дүнтэй байсныг нь тодорхойлж, эдгээрт үндэслэн агаарын бохирдлыг бууруулах асуудлыг тууштай анхаарах;
- (б) Чөлөөтэй шилжих хүний эрхийг хязгаарлахаас зайлсхийх;
- (в) Бохирдуулагчдын утаа ялгаруулалтанд шаардлагатай төлбөрийг ногдуулах зэргээр одоо байгаа хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэх, Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг төсөвлөх;
- (г) Нүүрс ашиглахаас зайлсхийж, эрчим хүчний сэргээгдэх эх үүсвэр, ялангуяа салхи болон нарны эрчим хүчийг эрчимтэй нэвтрүүлэх;
- (д) Агаар бохируудагчдын нягтаршил болон ялгаруулалтын талаар тоо баримтыг олж авах, нийтэд нээлттэй болгох механизмыг сайжруулах;
- (е) Тоосжилтын бохирдлын хяналт шинжилгээ, зохицуулалтыг бий болгох.

85. Монгол Улс өөрийн ашигт малтмал, уул уурхайн хууль тогтоомжоо хянах явцад иргэний нийгмийн оролцох боломжийг олгож, мэдээллэлээр хангах хэрэгтэй. Тусгай Илтгэгч Монгол Улсад дараах зүйлсийг санал болгож байна:

- (а) Уурхайнуудын нөхөн сэргээх стандартыг тодорхой болгож, сайжруулах, нөхөн сэргээх ажиллагааны хяналтыг сайжруулах;
- (б) Орон нутгийн нийгмийн бүлгүүдийг уурхайн талаар зөвлөдөх уулзалт, хэлэлцүүлэг явуулахад нь зориулж илүү урт хугацаа олгох;
- (в) Уул уурхайн компаниуд болон орон нутгийн эрх бүхий байгууллагуудын хооронд байгуулсан гэрээний ил тод байдлыг сайжруулах;
- (г) Уурхайнуудын байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд байгаль орчны үнэлгээний үр дүнг харгалзан үзэх;
- (д) Нөхөн сэргээх санд уул уурхайн компаниудын төлөх төлбөр болон орон нутгийн санд төлөх ашигт малтмал ашигласны төлбөрийг бүрэн ил тод болгох;
- (е) Оюу Толгой уурхайн хооронд үүссэн зөрчлийг эергээр шийдвэрлэсэн туршлагыг харгалзан үзэж, малчид болон бусад нөлөөнд өртсөн нийгмийн бүлгүүдэд гомдол гаргах механизмыг бий болгох.

86. Мөн Тусгай Илтгэгч Монгол Улсыг дараах арга хэмжээг түргэн хугацаанд авч хэрэгжүүлэхийг санал болгож байна. Үүнд:

- (а) Алт-2 саналын стратегийн байгаль орчны үнэлгээг хийж, Алт-1-ийн үр дагаврыг нөхөн сэргээх, нөхөн төлбөр олгох;
- (б) Уул уурхайн компаниуд бүхий л холбогдох хууль тогтоомжуудыг дагаж мөрдөх явдлыг хангахын тулд Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын уул уурхайн үйл ажиллагааг шалгах төсвийг нэмэгдүүлэх;
- (в) Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн зөвлөлийн зөвлөмж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн дүгнэлтийн дагуу авлигыг устгах хүчин чармайлтаа эрчимжүүлэх.

87. Байгалийн унаган төрхийг хадгалахтай холбоотойгоор Монгол Улсын өөрийн тусгай хамгаалалттай бүс нутгаа тэлэх төлөвлөгөөг Тусгай Илтгэгч сайшааж байна. Тэрээр Монгол Улсыг хамгаалалттай бүс нутгууд нь тус улсын төрөл бүрийн экосистем, төрөл зүйлийн амьдрах газрыг хамрах явдлыг хангаж, хяналт шинжилгээ, хэрэгжүүлэлтэд зарцуулах хөрөнгөө илүү их хэмжээгээр нэмэгдүүлэхийг уриалж байна.

88. Тусгай Илтгэгч дор дурдсан арга хэмжээнүүдийг хамааруулан байгалийн унаган төрхийг хадгалах хууль тогтоомжоо богино хугацаанд сайжруулахыг уриалж байна. Үүнд:

- (а) Тусгай хамгаалалттай бүс нутгийг тогтоох, удирдах удирдамжийг илүү тодорхой болгох;
- (б) Экосистем болон төрөл зүйлийн статусыг хамааруулан биологийн олон янз байдлыг хадгалах талаар системтэй, бүрэн мэдээллэлтэй болох;
- (в) Хамгаалалттай бүс нутгийн хяналт шинжилгээ хийх, энэ хяналтанд орон нутгийн нийгмийн бүлгүүдийг түлхүү оролцуулах;
- (г) Ан хийх болон байгалийн экосистемийг бусад байдлаар ашиглахыг хязгаарлахдаа уламжлалт бүлгүүдийн хүний эрхийг хүндлэх.

89. Мэдээлэл, олон нийтийн оролцоо болон арга хэрэгслийн хүртээмжтэй байдалтай холбоотойгоор Тусгай Илтгэгч Монгол Улсад дараах зүйлсийг уриалж байна. Үүнд:

- (а) Байгаль орчны чанар болон аюул заналын талаар, ялангуяа агаарын чанар, усны бохирдол, уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг олж авах, нийтэд нээлттэй болгох механизмыг сайжруулах;
- (б) Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, нөхөн сэргээлтийн тайлан, байгаль орчны менежментийн тайлан болон бусад холбогдох мэдээллийг илүү хүртээмжтэй болгох явдлыг хангах;
- (в) Уул уурхайн төслүүдийн талаар шийдвэр гаргах явцад иргэний нийгэм болон хамааралтай хувь хүмүүсийн оролцоог бодитоор хангах;
- (г) олон нийтийн эрх ашгийн төлөөх шүүхийн маргаанд тэмдэгтийн хураамж болон бусад хураамжаас чөлөөлөх заалтыг хэрэгжүүлэх зэргээр байгаль орчны маргаанд нэхэмжлэл гаргах саад бэрхшээлийг багасгах;
- (д) байгаль орчны асуудлаар хууль хэрэгжүүлэх болон шүүхийн боловсон хүчнийг сургах.

90. Тусгай Илтгэгч Засгийн газрыг байгаль орчны гол өмгөөлөгч бөгөөд байгаль орчны мэдээлэл, гомдлын гол цэг болон ажиллах чиг үүрэг бүхий байгаль орчны омбудсмэний албан тушаал бий болгохыг санал болгож байна. Байгаль орчны омбудсмэны ажил нь бусад холбогдох байгууллагуудын үйл ажиллагаатай давхцахгүй. Харин энэхүү албан тушаал нь Засгийн газарт нэг төрлийн “ногоон хаалга” болно. Байгаль орчны асуудалтай холбоотой гомдол гаргах буюу мэдээлэл хүсч буй Монголчууд байгаль орчны омбудсмэний албатай холбогдох ба тус алба нь тухайн асуултыг зохих газар луу нь дамжуулж, тухайн этгээд хариугаа шуурхай авч байгаа эсэхэд хяналт тавина. Мөн омбудсмэн нь Засгийн газрын байгаль орчны мэдээллийг нэгтгэж, олон нийтэд нээлтэй байлгах асуудлыг хариуцна. Омбудсмэн нь мөн төлөвлөгдөж буй уурхайн үйл ажиллагаанаас гарч болзошгүй үр нөлөөг тодорхойлоход тусалж, уул уурхайн компаниудтай гэрээ хийх талаар хэлэлцээр хийхэд нь орон нутгийн нийгмийн бүлгүүдэд дэмжлэг үзүүлэх юм.

91. Тусгай Илтгэгч Монгол Улсыг Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргах ажиллагаанд олон нийт оролцох болон шударга ёсны хүртээмжтэй байдлын Конвенц (Аархус Конвенц)–д түргэн хугацаанд нэгдэн орохыг уриалж байна. Энэхүү Конвенцид нэгдэн орсноор олон улсын хамтын нийгэмлэгээс Засгийн газарт олон улсын стандартуудыг хангах, үр дүнтэй хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлэх боломж нээгдэнэ.

92. Байгаль орчны хамгаалагчтай холбоотойгоор Тусгай Илтгэгч Засгийн газрыг дараах арга хэмжээнүүдийг яаралтай авч хэрэгжүүлэхийг уриалж байна. Үүнд:

- (а) Төмөрсүхийн Лхагвасүмбэрэлийн үхэлд өөрөө мөрдөн байцаалт явуулж, түүний хариуцан ажиллаж байсан байгаль хамгааллын байгууллагын бусад гишүүд дарамт сүрдүүлэгт өртөхгүй байх нөхцлийг бүрдүүлэх;
- (б) Хүний Эрхийн Үндэсний Комиссын боловсруулсан хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах, үйл ажиллагааг нь дэмжих хуулийг батлах.

## **10.6 НҮБ–ЫН ХҮНИЙ ЭРХ, УНДНЫ УСНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН ТУСГАЙ ИЛТГЭГЧ ЛЕО ХЕЛЛЕРЫН МОНГОЛ УЛСАД ХИЙСЭН АЙЛЧЛАЛЫН ДҮГНЭЛТ**

Улаанбаатар хот

2018 оны 4 дүгээр сарын 20–ны өдөр

Сайн байна уу,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрх, ундны усны аюулгүй байдал, ариун цэврийн байгууламжийн асуудал хариуцсан Тусгай илтгэгчийн хувьд Монгол Улсын Засгийн газрын урилгаар 2018 оны 4–р сарын 9–20–ны өдрүүдэд Монгол Улсад хийсэн албан айлчлалынхаа төгсгөлд өнөөдөр би та бүхэнд хандаж байна.

Юуны өмнө, МУ–ын Засгийн газарт намайг урьж, айлчлалыг зохион байгуулсанд талархал илэрхийлье. Айлчлалын үеэр миний бие төв болон орон нутгийн захиргааны байгууллагын албан хаагчид, олон улсын байгууллагууд, олон улсын хөгжлийн санхүүжүүлэгч байгууллагууд, иргэний нийгмийн төлөөлөл болон жирийн иргэдтэй уулзлаа. Цаг заваа зарцуулан надтай ярилцаж, гэртээ урин залсан хүмүүст онцгойлон талархал илэрхийлж байна. Мөн энэхүү айлчлалыг зохион байгуулахад туслалцаа үзүүлсэн НҮБ–ын Суурин зохицуулагчийн ажлын албанд баярлаж байгаагаа илэрхийлье. Олон нийтийн сүлжээнд гарч байсан айлчлалын явцын мэдээг сонирхон уншиж байсан жирийн Монголчуудад баярлалаа.

Монгол Улсад ажиллах хугацаандаа хийсэн үнэлгээнийхээ урьдчилсан дүгнэлтээс өнөөдөр та бүхэнд танилцуулж байна. Үнэлгээний тайлангийн эцсийн бөгөөд дэлгэрэнгүй хувилбарыг энэ оны 9 дүгээр сард болох НҮБ–ын Хүний Эрхийн Зөвлөлийн 39 дүгээр чуулганд танилцуулах болно.

Энэ удаагийн айлчлалын үеэр миний анхаарлаа хандуулсан гол асуудлууд бол хүний хэрэглээнд зориулсан ундны усыг иргэдэд хүргэх үйлчилгээний хүртээмж, мөн жорлон ба халуун усанд орох, хувийн ариун цэврийг сахих газар зэрэг ариун цэврийн байгууламжуудын хүртээмжийн асуудал байлаа.

Эрс тэс уур амьсгалтай Монгол орны хувьд ундны ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийн асуудал олон жилийн турш Засгийн газрын шийдвэрлэвэл зохих асуудал байсаар байгаа билээ. Ундны ус, ариун цэврийн байгууламжийн салбарт зарим үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлсэн хэдий ч Монгол Улс нь Мянганы Хөгжлийн Зорилго 7–ийн “2015 он гэхэд баталгаат ундны усны хангамжгүй, сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдаагүй хүн амын тоог хоёр дахин бууруулна” гэсэн зорилгод хүрч чадаагүй билээ. Тогтвортой Хөгжлийн үзэл баримтлал батлагдсанаас хойш анх удаа хийгдсэн хяналтын ажил болох Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ), НҮБ–ын Хүүхдийн Сангаас (НҮБХС) хамтран хэрэгжүүлсэн Хяналтын Хөтөлбөрийн тайланд дурдсанаар, 2015 онд Монгол Улсын нийт хүн амын 84 хувь нь ундны усны суурь үйлчилгээг хүртдэг бол 59 хувь нь энгийн ариун цэврийн байгууламжтай гэжээ. Энгийнээр хэлбэл, Монголчуудын дийлэнх хэсэг нь ундны усаа худгаас авдаг ба нийт хүн амын

тал шахуу хувь нь нүхэн жорлонд бие засдаг гэсэн үг юм. Харин эдгээр тоо баримт нь Тогтвортой Хөгжлийн Зорилгуудын 6.1 ба 6.2-т “аюулгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан үйлчилгээ”-тэй холбоотой үзүүлэлтээс харьцангуй доогуур байна. 2015 оны байдлаар, нийт хүн амын зөвхөн дөрөвний нэг хэсэг нь гэртээ цоргоноос ус авдаг бол дөнгөж 13 хувь нь л бохир усны нэгдсэн сүлжээнд холбогдсон байна гэсэн үг юм. Эдгээр тоо баримт нь ундны ус, ариун цэврийн байгууламжийн асуудалд МУ-ын Засгийн газраас тэргүүлэх зэргийн ач холбогдол өгч анхааран ажиллах шаардлагатай байгааг илтгэж байна.

\* \* \*

Хоёр долоо хоног үргэлжилсэн айлчлалынхаа хугацаанд би хотод болон хөдөө орон нутагт амьдардаг, ялангуяа нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг Монголчуудын ундны усны хангамж, ариун цэврийн байгууламжийн нөхцөл байдалтай өөрийн биеэр танилцахад ундны ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмж янз бүрийн түвшинд харилцан адилгүй байгаа нь харагдлаа. Хүний эрхийн байр сууринаас авч үзэхэд ийм төрлийн үйлчилгээг авах явдалд тэгш бус байдал ажиглагдаж байгаа нь сэтгэл зовниулсан асуудал яах аргагүй мөн юм. Баталгаатай ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах хүний эрхийн норматив агуулга болох хүртээмж, хангамж, боломжит үнэ, чанар/аюулгүй байдал, хүлээн зөвшөөрөгдөх зэрэг өнцгөөс Монгол Улсад байгаа тэгш бус байдлыг авч үзэх болно.

## **1. Ундны ус, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээний хүртээмж тэгш бус байна**

### **А. Хот, хөдөөгийн ялгаа**

Монгол Улс нь нутаг дэвсгэрийн хэмжээгээр дэлхийн 17 дахь том орон хэдий ч хүн ам нь хамгийн сийрэг суурьшсан орнуудын нэг билээ. Гурван сая хүний бараг хагас нь нийслэл Улаанбаатар болон Дархан, Эрдэнэт хотуудад төвлөрөн амьдарч, хүн амын үлдсэн хэсэг нь хөдөө орон нутагт тархан суурьшдаг.

Хотууд хурдацтай хөгжиж, хөдөөгөөс хот руу иргэд олноор шилжин суурьшиж байгаагийн улмаас ундны усны болон ариун цэврийн байгууламжийн хүртээмж хотод болон хөдөөд ялгаатай байна. ДЭМБ/НҮБХС-аас гаргасан Хяналтын Хөтөлбөрийн тайланд, 2015 оны байдлаар Монголын хотуудад оршин сууж буй иргэд бараг бүгд (94 хувь нь) ундны усаар хангагдаж байсан бол хөдөөгийн хүн амын зөвхөн тал нь (56 хувь) ийм түвшний үйлчилгээг авч байжээ. Ариун цэврийн байгууламжийн хувьд ч хот, хөдөөгийн ялгаа их буюу хотын хүн амын 66 хувь нь энгийн ариун цэврийн байгууламжтай байсан бол хөдөөд зөвхөн 41 хувь нь жорлонтой байжээ.

Улаанбаатарт байхдаа, мөн Дундговь, Өмнөговь аймгуудаар явахдаа энэхүү илт ялгааг би өөрийн нүдээр харсан. Засгийн газраас өгсөн мэдээгээр, нийт 334 сумын дөнгөж 20 сумын төв хэсэгт нь ус хангамжийн төвлөрсөн шугам сүлжээ байна. Бусад сумдын оршин суугчид нь улсын төсвийн хөрөнгөөр, хувийн хэвшлийн ААН-ийн санхүүжилтээр, эсвэл хувь хүний хөрөнгөөр баригдсан нийтийн болон хувийн худгаас ундны усаа авдаг байна. Улсын

хэмжээнд нийт 34 сумдын оршин суугчдын ундны усны чанар нь Монгол Улсын стандартад нийцэхгүй байгаа нь туйлын ихээр санааг минь зовниулж байна. Иймд, холбогдох төрийн захиргааны төв байгууллагууд, орон нутгийн удирдлагуудтай хамтран эдгээр сумдыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усны эх үүсвэртэй болгох тал дээр яаралтай арга хэмжээ авахыг зөвлөж байна.

Хөдөөгийн иргэдийн ундны ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг сайжруулах зорилгоор Барилга, Хот Байгуулалтын Яамнаас Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжил” төслийг хэрэгжүүлсэн байна. Даланзадгад сумын нэгэн айлд орж үзэхэд тэднийх цэвэр, бохир усны төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон, гэртээ цоргоноос ус авчихдаг тул ая тухтай, сайхан амьдарч байв. Харин тэднийхээс холгүй нэгэн байшинд тэтгэврийн мөнгөөрөө амьжиргаагаа залгуулдаг хоёр хөгшин амьдардаг ба тэднийх төвийн шугам сүлжээнд холбогдохын тулд нэг удаа төлөх 800,000 төгрөгийн (ойролцоогоор 340 ам.доллар) хураамжийг төлөх боломжгүй учраас усаа худгаас зөөдөг гэж байлаа.

Суманд төвлөрсөн шугам сүлжээ байдаг ч нэмэлтээр жорлон, усанд орох байр, ус халаах бойлер барихад шаардагдах санхүүгийн хөрөнгийг өрхүүд өөрсдөө гаргах ёстой учир айл болгонд тийм боломж нь алга байна. Орон байраа цэвэр, бохир усны шугамд холбож, боловсон жорлонтой болохын тулд байшингаа өөрчлөн барихад бүр ч их зардал шаардагдах нь дамжиггүй. Иймд Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын яамнаас тусгай хөтөлбөр боловсруулж, эдийн засгийн боломжгүй, эмзэг бүлгийн өрхүүдэд цэвэр бохир усны төвийн шугам сүлжээнд холбогдоход нь дэмжлэг үзүүлэх, ингэхдээ хөдөө орон нутгийн өрхүүдэд онцгой анхааран ажиллахыг санал болгож байна. Үүний зэрэгцээ төв засгийн газраас орон нутгийн захиргаадад татаас олгох замаар өрхүүдийг төвлөрсөн шугам сүлжээнд холбох ажлыг зохион байгуулахыг уриалж байна.

Ундны ус, ариун цэврийн байгууламжийн хувьд хот-хөдөөгийн ялгааг арилгахын төлөө хүчин чармайлт гарган ажиллах, ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах үйлчилгээг сайжруулахад шаардагдах санхүүгийн болон техникийн дэмжлэг дутмаг байдаг хөдөөгийн оршин суугчдад онцгой анхаарал хандуулан, нэн тэргүүн ач холбогдол өгч асуудлыг шийдвэрлэхийг МУ-ын Засгийн газраас шаардаж байна.

### **В. Орон сууцны болон гэр хорооллын ялгаа**

Ундны ус, ариун цэврийн байгууламжийн хангамжийн хувьд хотын оршин суугчдын дунд ялгаа байгаа нь Монгол орны цаг агаарын байдалтай холбоотой юм. Орон сууцанд амьдардаг айл, гэр хорооллын айлаас ялгаатай гол зүйл нь тухайн өрхийн орон байр нь төвлөрсөн цэвэр бохир усны сүлжээнд холбогдсон, холбогдоогүйгээс хамаардаг. Монгол гэр бол мал аж ахуй эрхэлдэг Монголчуудын нүүдлийн амьдралын хэв маягийг илэрхийлсэн эсгийгээр бүрсэн дугуй хэлбэрийн өвөрмөц зөөврийн сууц юм. Нүүдлийн мал аж ахуй эрхэлдэггүй, гол төлөв хөдөөгөөс шилжин суурьшсан айл өрхүүд ихэвчлэн орон сууц худалдаж авах эдийн засгийн боломжгүй байдаг тул хотын захын хорооллуудад гэрээ барин оршин суудаг юм.

Ерөнхийдөө Монголын өвөл их хүйтэн ба удаан, зарим жилүүдэд 6 сар ч үргэлжлэх нь бий. Хүйтний улирлын оргил үед агаарын хэм цельсийн -35, -40 хүрдэг. Өнгөрсөн

Пүрэв гаригт цас орохыг харснаар өвлийн төгсгөлийг би өөрийн биеэр мэдэрсэн билээ. Өвлийн улиралд гэр хорооллын оршин суугчдад ундны ус, ариун цэврийн байгууламжийн асуудал нэлээн хүндрэлтэй болдог. Орон сууцанд амьдардаг өрхүүд голдуу төвийн халаалтын системд холбогдсон байдаг тул хүйтэн өвлийг ажрахгүй давдаг. Шугам сүлжээний бүрэн бүтэн байдлыг шалгаж, шаардлагатай тохиолдолд засвар үйлчилгээ хийх замаар төмөр хоолой хөлдөхөөс хамгаалж, өвлийн бэлтгэлийг хангадаг. Харин гэр хорооллын айлуудын хувьд ундны усаа 500 метрийн зайнд байрлах худгаас зөөдөг, бие засахын тулд гэрээсээ гарч халаалтгүй нүхэн жорлонд ордог тул хүйтнээс дайжих боломжгүй юм.

Улаанбаатарчуудын тал гаруй хэсэг нь хотын захын хорооллуудад гэрт амьдардаг тул орон сууцны хороолол, гэр хорооллын ялгаа илт харагдаж байлаа. Жишээлбэл, нийслэлийн Налайх дүүргийн хүн амын 20 хувь нь орон сууцанд оршин суудаг бол 80 хувь нь цэвэр, бохир усны төвлөрсөн системд холбогдоогүй гэр хорооллуудад амьдарч байна. Улаанбаатарын гэр хороолол урьдчилсан төлөвлөлтгүйгээр хүрээгээ улам бүр тэлж байгаа нь ундны ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийн асуудлыг улам бүр хурцдуулж байна. Хөдөөгөөс хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний улмаас нийслэлийн хүн амын тоо эрчимтэй өссөөр, харин ундны ус, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээг хүргэхэд шаардлагатай дэд бүтцийг барих ажлын хурд энэ өсөлтийг гүйцэхгүй байна.

Зөвхөн хотод төдийгүй, хөдөө орон нутагт ч тэгш бус байдал ажиглагдаж байв. Миний очсон Дундговь, Өмнөговь аймгийн сумын төвийн орон сууцны хороолол, гэр хорооллын ялгаа нь Улаанбаатарын орон сууцны болон гэр хорооллын ялгааг санагдуулж байлаа. Жишээлбэл, Даланзадгадын орон сууцны байруудад амьдардаг бүх айл (4,000 орчим хүн) төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон байхад 16,000 орчим гэр хорооллын оршин суугчдын зөвхөн 30 хувь нь л ийм холболт бүхий байшинд суудаг байна. Гэр хороололд амьдардаг хүмүүсийн хувьд төвлөрсөн дэд бүтцэд холбогдоогүйн улмаас амьдралын чанар өөр байна.

Улаанбаатар хотын оршин суугчдын бараг 45 хувь нь ус түгээх төвлөрсөн системд холбогдсон байдаг бол гэр хорооллын оршин суугчид нь ундны болон хэрэглээний усаа худгаас зөөдөг. Улсын өмчийн худгуудын зарим нь усаа төвийн шугамаас авдаг бол заримд нь усыг машинаар зөөж авчирдаг, харин гүний худгуудын ихэнх нь хувийн эзэмшилд байдаг байна.

Одоогийн байдлаар Улаанбаатар хотын Ус Сувгийн Удирдах Газрын (УСУГ) харьяаны нийт 600 худаг гэр хорооллуудад үйл ажиллагаа явуулж байна. Нийслэлийн хүн амын бараг 60 хувь буюу 200,000 гаруй өрх гэр хорооллуудад оршин суудаг байхад дунджаар 300 өрх тутамд нэг худаг ногдож байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм.

Гэр хорооллын хэд хэдэн худаг дээр би очиж үзлээ. Ихэнх худаг долоо хоногийн 2 өдөрт нь амардаг, мөн шөнийн цагаар хаалттай байдаг нь ундны усны хүртээмжийг хязгаарлаж байна. Энэ асуудлыг шийдэхийн тулд хэд хэдэн газар “ухаалаг” буюу автоматаар ус олгодог худгийг байгуулсан байв. Одоогийн байдлаар Улаанбаатар хотын гэр хорооллуудад 100 орчим ухаалаг худаг ажиллаж байгаа бол хөдөө орон нутагт ч, жишээ нь Даланзадгадад, туршилтын журмаар хэд хэдэн ухаалаг худгийг ашиглалтад

оруулсан байна. Нийслэлийн Налайх дүүрэгт ухаалаг худагтай болох нь гэр хорооллын оршин суугчдыг ундны усаар тасралтгүй хангах гол шийдэл гэж үздэг юм байна.

Ундны ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмж янз бүр байгаа учраас хэрэглэж буй усны хэмжээ ч гэр хороолол, орон сууцны хороололд харилцан адилгүй байна. Орон сууцны нэг өрх өдөрт дунджаар 200 литр ус хэрэглэдэг бол гэрт амьдардаг өрхийн нэг гишүүн өдөрт 7–15 литр ус хэрэглэдэг гэсэн тооцоо байдаг. Худгаас 50–60 орчим литр ус авч байсан нэгэн эртэй би ярилцсан юм. Тэднийд 3 том хүн, 7 хүүхэд амьдардаг гэв. Энэ хүний авсан ус нь тухайн гэр бүлийн гишүүдийн хувцас угаах, усанд ороход хүрэлцэхгүй нь ойлгомжтой. Тэгэхлээр, гэр хорооллын нэг хүний хэрэглэж буй усны хэмжээ олон улсын стандартаас доогуур байна. Надад тайлбарласнаар, гэрт амьдардаг айлууд аль болох бага ус авдаг, учир нь худгаас ус зөөх нь хүндрэлтэйгээс гадна хүйтний улиралд хөрс хөлдчихдөг тул бохир усыг асгах боломж хязгаарлагдмал болдог гэнэ.

Үйлчилгээний түвшин ялгаатай байгаа учраас усны төлбөр ч өөр өөр байна. Нийслэлийн гэр хорооллуудад ердөө 600 нийтийн худаг ажилладаг тул оршин суугчид ундны усаа ихэвчлэн хувийн худгаас авч, литр тутамд 2 төгрөг төлж байна. Харин нийтийн худгийн усны үнэ литр тутамд 1 төгрөг байдаг юм. Усыг худгаас зөөдөг тул гэр хорооллын иргэд хувийн халуун усны газарт очиж усанд ордог байна. Жишээлбэл, Дундговь аймгийн иргэд халуун усанд орохдоо 1,500 төгрөг буюу 0.60 ам.доллар орчим төлдөг бол нийслэлийн Баянзүрх дүүргийн Гачуурт хороололд халуун усанд ороход 2,500 төгрөг буюу 1 ам.доллар орчим төлдөг гэнэ. Миний ажигласнаар, хөдөөд ч, хотод ч халуун усны газрууд цэвэрхэн байсан, харин аль алинд нь үйлчлүүлж буй хүмүүс харагдсангүй.

Монголд нэг өрхийн сарын орлого дунджаар 220 ам.доллар орчим байдаг тул өнөр өтгөн айлуудын хувьд халуун усанд орох нь нэлээд өндөр зардалтай байдаг. Халуун усны газрын төлбөр өндөр учраас усанд орох давтамж цөөрнө. Эдийн засгийн хувьд өндөр зардалтайгаас гадна гэр хорооллын оршин суугчид худгаас усаа зөөх, хувийн халуун усны газарт очих усанд орох зэрэгт багагүй цаг заваа зарцуулж, мөнгөн бус зардал гаргаж байдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Миний ажигласнаар, гэр хорооллын айлуудын жорлон нь гэрээсээ тусдаа, гэхдээ хашаан дотроо байсан ба ихэвчлэн аюулгүй байдлын шаардлага хангаагүй байв. Хүйтний улиралд айлууд амьдардаг гэрээ халаахын хажуугаар бие засдаг жорлонгоо дулаан байлгах асуудалтай тулгардаг гэнэ. Нүхэн жорлон нь дүүрсэн тохиолдолд шинээр жорлон барихын тулд ажилчдыг хөлсөлж нүх ухуулах зэрэгт багагүй зардал шаардагддаг байна.

Ийм нөхцөл байдалд ундны ус, ариун цэврийн байгууламжийн тэгш бус хүртээмжийн асуудлыг шийдвэрлэхэд ямар арга зам хамгийн оновчтой вэ гэдэг хүндхэн асуулт засгийн газрын өмнө тулгарч байна. Юуны өмнө, гэр хорооллын оршин суугчдын ундны ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг сайжруулах чиглэлээр төрөөс багагүй хүчин чармайлт гарган ажиллаж байгааг тэмдэглэх нь зүйтэй. Гэсэн хэдий ч, төр захиргааны байгууллагууд болон бусад оролцогч талуудын төлөөлөлтэй уулзаж байх явцад гэр хороололд ундны ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг сайжруулахын тулд ус дамжуулах хоолой татах, шинээр худаг барих, ухаалаг худгийн тоог нэмэгдүүлэх хэрэгтэй гэж тэд ярьж байв. Ер нь тэд гэр хороололд худгаас ус зөөх, нүхэн жорлонд бие



засах явдал бол хэвийн үзэгдэл мэт хүлээн авч байлаа. Мэдээж хэрэг, ундны ус болон ариун цэврийн байгууламжаар хангагдах хүний эрхийн хэрэгжилтийн нөхцөлийг бага багаар л сайжруулна. Энэ нь хүний эрхийн хэрэгжилтийг тогтмол ахиулан сайжруулах зарчимд нийцнэ. Гэхдээ одоо хэрэгжүүлж буй ажил, боловсруулж буй төлөвлөгөөндөө ч нөхцөл байдлыг дээрдүүлэх зүйл хийж болно гэдгийг би онцлон тэмдэглэмээр байна. Даланзадгадад төвлөрсөн шугам сүлжээг гэр хороолол руу татсан туршлага үүний нэгэн жишээ юм. Хотод ч, хөдөөгийн суманд ч, гэр хороололд амьдардаг иргэд нь орон сууцны оршин суугчдын нэгэн адил ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах боломж байна.

Орон сууцны хороолол, гэр хорооллын ялгааг арилгахын тулд богино болон урт хугацааны төлөвлөгөө боловсруулж гэр хорооллыг иргэдийн ундны ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг аажмаар сайжруулахыг Засгийн газарт онцгойлон анхааруулж байна.

### **С. Нүүдлийн аж ахуй эрхэлдэг хүн ам**

Ундны ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийн тэгш бус, эмзэг байдал малчин иргэдийн хувьд ч байна. Монголчуудын ихээхэн хэсэг нь мал маллаж нүүдэлчин ахуйгаар бэлчээр сэлгэн амьдардаг. Тэд ундны усаа гар худгаас, зарим тохиолдолд гадаргын уснаас авч хэрэглэдэг. Улаанбаатараас Өмнөговь руу явж байх замд нэгэн малчин өрхийн ундаалдаг худгийг би харсан. Тэр худаг нэлээн гүехэн, малын ялгадас хөрсний бохирдолд өртөж болзошгүй харагдсан. Энэ худгаас тэр айл өөрсдөө ч ундаалж, малаа ч усалдаг учраас худгаас гарах багахан усаа хэмнэх шаардлагатай байдгийг би ойлгосон.

Малчид мөн гадаргын цэвэр усны эх үүсвэрүүдээс ундаалдаг. Монгол орны хойд бүс нутагт хувиараа алт олборлогч иргэд ихэвчлэн зохион байгуулалтгүй, эмх замбараагүй олборлолт явуулж, гадаргын усыг химийн бодисоор бохирдуулж, улмаар энэ нь нүүдлийн аж ахуй эрхэлдэг хүн амын ундны усны чанарт муугаар нөлөөлж байна. Учир нь усанд агуулагдаж болзошгүй хүнцлийн хор нь өнгөгүй, үнэргүй тул ийнхүү бохирдсон усыг нүүдэлчин хүн ам ундандаа хэрэглэсээр байж болох юм.

Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн яамны чиг үүрэгт бэлчээрийн усны асуудал, малчдыг ундны усаар хангах асуудал багтдаг. Сүүлийн арав гаруй жилийн турш зарим арга хэмжээг авч хэрэгжүүлсэн ч малчдад ус хомс хэвээр байсаар байна. Нийт 9 мянга гаруй худаг байдаг (үүний 70 орчим хувь нь гүехэн гар худаг) гэсэн хэдий ч энэ нь малчдын усны хэрэгцээг хангаж чадахгүй байна. Мөн эдгээр худгийн дийлэнх нь гүехэн гар худаг тул усны чанар учир дутагдалтай байх асуудал байсаар байна. Иймд Монгол Улс тодорхой арга хэмжээ авч, малчин өрхүүдийн аж төрөх ёсны онцлогт тааруулан ундны усны хүртээмжийг сайжруулах, малчин биш бусад иргэдийн түвшинтэй ижил болгох шаардлагатай байна. Малчдыг ундны болон малаа услах усаар бүрэн хангаад өгчихвөл хөдөөгөөс хот суурин газар руу чиглэсэн шилжих хөдөлгөөн буурахад хувь нэмэр оруулах болов уу гэж бодож байна.

**D. Хүүхдүүд, охид ба боловсролын байгууллагын ариун цэврийн байгууламжийн асуудал**

МУ-ын Засгийн газраас 2015 онд “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлага” боловсруулан гаргасан байдаг. Өнөөдөр энэхүү стандартын хэрэгжүүлэх шаардлагатай нийт сургуулиудын талаас илүү хувь нь гадаа жорлонтой байна. Миний харсан сургуулийн гаднах жорлонгийн ариун цэвэр, эрүүл ахуйн байдал туйлын хангалтгүй, аюултай байсан. Харин нийслэлийн Налайх дүүргийн болон Гачуурт хорооны сургуулийн шинээр баригдсан жорлонгууд их цэвэрхэн байлаа. МУ-ын Засгийн газар энэ ялгааг арилгаж, сургуульд суралцдаг бүх хүүхдүүдийн ариун цэврийн байгууламжийн хүртээмж, нөхцөлийг ижил болгох шаардлагатай байна.

Нүүдэлчин Монголчуудын амьдралын хэв маягтай салшгүй холбоотой нэгэн онцлог бол дотуур байртай сургуулиуд юм. Малчин өрх нь жилдээ хэд хэдэн удаа бууриа сэлгэж, нүүдлийн аж ахуй эрхэлдэг учраас тэдний хүүхдүүд боловсрол эзэмшихийн тулд 9 сар үргэлжлэх хичээлийн жилийн турш дотуур байранд сууж, хичээлдээ явдаг юм. Хөдөө ажиллах хугацаандаа би хэд хэдэн сургуулийн дотуур байраар орж үзлээ. Тэдгээрийн заримд нь хүүхдүүд ая тухтай орчинд, байран дотроо бие засаж, нүүр гараа угаах боломж бүрдсэн байв. Харин зарим дотуур байрны хүүхдүүд бие засахын тулд гадаа гарч, аюултай, халаалтгүй, усгүй нүхэн жорлонд орохоос өөр сонголтгүй байв. Хөдөөгийн хүүхдүүдийн хувьд дотуур байр нь тэдний гол сууц болдог учраас дотуур байрны ус, ариун цэврийн байгууламжийн хангамжийн асуудлыг холбогдох байгууллагууд анхааралдаа авч шийдвэрлэхийг зөвлөж байна.

Ялангуяа охид сарын тэмдэг ирсэн үедээ сургууль дээр нь шаардлага хангасан ариун цэврийн өрөө байхгүйгээс ихээхэн хүндрэлтэй байдаг. Засгийн газраас 2015 онд хийсэн стандартын биелэлтийн шалгалтын тайланд дурдагдсанаар, сарын тэмдэг ирсэн үедээ охид гадаа жорлонд орохыг хүсдэггүй учраас хичээлээ таслах нь элбэг тохиолддог байна. Боловсон жорлонгийн асуудлаас гадна усны хангамж, халуун усанд орох боломж зэрэг охидын эрүүл ахуй, ариун цэврийн асуудалд учир дутагдалтай зүйлс байсаар байна. Сургуулийн бүх дотуур байрыг халуун устай болгох, сарын тэмдэг нь ирдэг насны охидод ариун цэврийн хэрэглэл олгох зэрэг асуудалд ач холбогдол өгөхгүй байна. Охидод зориулсан сарын тэмдгийн эрүүл ахуйн хөтөлбөр боловсруулж ерөнхий боловсролын сургуулиуд болон дотуур байруудад хэрэгжүүлдэг болохыг БСШУСЯ-д зөвлөж байна.

**E. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнууд**

Тэгш бус байдлын өөр нэгэн илрэл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ахмадуудтай холбоотой илэрч байгааг би анзаарсан. Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны мэдээллээр 93,000 өрхийн нэгд нь дор хаяж нэг хөгжлийн бэрхшээлтэй хүн байна. Эдгээр өрхийн 52 хувь нь орон сууцанд амьдардаг бол үлдсэн нь гэр хороололд амьдарч байна. Төвийн шугам сүлжээнд холбогдоогүй орчинд амьдрах нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ахмад настнуудад улам их хүндрэл бэрхшээл учруулдаг.

Монголд ажиллах хоёр долоо хоногийн хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй хүн ба хөдөлгөөний бэрхшээлтэй ахмадуудад тусгайлан барьсан ариун цэврийн байгууламж

(жорлон)–г зөвхөн Дундговь аймгийн Хулд сумын эмнэлэгт л харлаа. Хулд сум нийт 2400 хүнтэй бөгөөд энэхүү жорлонг хөгжлийн бэрхшээлтэй 50 хүнд л зориулан барьсан тусгай тоногосон жорлон байв: эдгээр хүмүүсийн 6 нь тэргэнцэр хэрэглэх шаардлагатай. Гэвч эрүүл мэндийн төвийн төлөөлөгчийн хүлээн зөвшөөрч байгаагаар, уг жорлон ч шаардлага хангахгүй байгаа. Үүнээс гадна чанар муутай гэр хорооллын замаар явж худгаас 20 литрийн саванд усаа авч, нааш цааш зөөх нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд амаргүй даваа юм.

\* \* \*

Одоогийн байдлаар ундны усны аюулгүй байдал, ариун цэврийн байгууламжийн хүртээмжээс болж тэгш бус байдал олон янзаар илэрч байна. Гэвч Монгол Улсад хүний эрх ба ундны усны аюулгүй байдал, эрүүл ахуйн байгууламжийн хүртээмжийг холбож ойлгох юм бол нөхцөл байдал эрс өөрчлөгдөнө. Монгол Улс хүний эрхийн олон улсын хэд хэдэн гэрээ, хэлэлцээрт, тэр дундаа Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактад нэгдэн орсон байдаг. Энэхүү Пактын дагуу амьдралын зохистой стандартыг мөрдөх, ялангуяа баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах тухай эрх үүргийг тусгасан байдаг. Монгол Улс нь дээрх гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн хүний эрхийг хангах үүргээ биелүүлэхэд саад болж буй зарим зохицуулалтын болон хэрэгжилтийн түвшний бэрхшээлүүдийн талаар би ажигласан зүйлсээ Та бүхэнтэй хуваалцъя.

## **2. Хэрэгжилтийн түвшинд тулгарах бэрхшээлүүд**

### **А. Ундны ус, ариун цэврийн байгууламжийн асуудал нь хүний эрхийн асуудал гэдгийг хүлээн зөвшөөрөөгүй**

Олон улсын түвшинд ундны ус, ариун цэврийн байгууламжийн асуудлыг хүний эрхийн асуудал хэмээн бүрэн хүлээн зөвшөөрдөг. Харин Монгол Улсын хувьд төрийн түшээ нараас эхлээд иргэний нийгэм, олон нийт зэрэг дийлэнх хүмүүс хүний эрх ба ундны усны аюулгүй байдал, ариун цэврийн байгууламжийн асуудал өөр хоорондоо нь холбоотой гэдгийг тодорхой ойлгохгүй, үүний утга учрыг олохгүй байгаа юм болов уу гэж надад санагдлаа. Усны хэрэглээ, ариун цэвэр орчинд амьдрах нь хүний эрх гэдгийг ойлгохгүй байгаа учраас Монгол Улсын Засгийн газрын нэгдэн орсон олон улсын хүний эрхийн гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг бүрэн хангаж чадахгүй байна.

Юуны өмнө хууль эрх зүй, бодлогын баримт бичигт хүний эрх ба ундны усны аюулгүй байдал, ариун цэврийн байгууламжийн тухай тусгаагүй байдаг нь ийнхүү иргэд нь мэдлэггүй байгаагийн нэг шалтгаан болдог. Монгол Улсын Үндсэн хуульд ус хэрэглэх, ариун цэвэр орчноор хангагдах хүний эрхийг тусгайлан заагаагүй байдаг ба зөвхөн 16 дугаар зүйлд “эрүүл, аюулгүй орчинд амьдрах” эрхийг тунхагласан байдаг. Тийм учраас шүүх байгууллагууд, шийдвэр гаргагчдын зүгээс тусгай тайлбар хийх шаардлага үүсдэг тул зөрчилтэй нөхцөл байдал үүсч болзошгүй юм. Улмаар баталгаатай ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах хүний эрхийн норматив агуулгын бүхэлд нь бус, зөвхөн заримыг л бодитоор хэрэгжүүлэх боломж байна.

Ус, ариун цэврийн тухай хууль, эрх зүйн орчин нь энэ утгаараа бүрэн бус гэж үзэж байна. 2011 онд батлагдсан Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль нь ус ханган нийлүүлэгч болон эцсийн хэрэглэгч хооронд байгуулах гэрээг зохицуулах хууль, эрх зүйн суурь болж байгаа юм. Энэхүү хууль нь ус хангамжийн хүрэлцээт байдал, хамрах хүрээтэй холбоотой асуудлыг зохицуулдаг хэдий ч ундны усны аюулгүй байдал, ариун цэврийн байгууламж ба хүний эрхийн хүрээг, тэр дундаа үнэ өртгийн хүртээмжтэй байдал, төлбөр төлж чадахгүй тохиолдолд ус хангамжийг таслахыг хориглох зэрэг асуудлууд энэ хуульд тусгагдаагүй байна. Нийгмийн хамгааллын хяналтгүйгээр хувийн хэвшлээс түгээдэг үйлчилгээг зохицуулдаг хуульд юуны өмнө хүний эрхийг хангах өнцгөөс хандах нь чухал юм. Өмнө нь дурдсанчлан Монголд ус хангамжийн үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн компаниуд ус түгээлтээс харьцангуй өндөр төлбөр авдаг бөгөөд төрийн байгууллагын зүгээс тэдгээрийн үйл ажиллагаанд тавьж байгаа хяналт тун сул, бараг үгүй гэж хэлэхэд болохоор байна.

Монгол Улсын Засгийн газар нь баталгаатай ундны ус хэрэглэх, ариун цэвэр орчноор хангагдах тухай хүний эрхийг Үндсэн хуулинд тусгахын сацуу бусад хууль, тогтоомж, журамд хүний эрхийг хамгаалах үүднээс хандаж байх нь зүйтэй. Улмаар Үндсэн хуулийн цэц нь ундны усны аюулгүй байдал, ариун цэврийн байгууламж ба хүний эрхийг зөрчсөнтэй холбоотой хэргүүдийг Захиргааны шүүхэд хаяглахаас өмнө шийдвэрлэх боломжтой болох юм. Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах хүний эрхийг хууль эрхзүйн хүрээнд хүлээн завшөөрч, бодлого хөтөлбөрүүдэд тусгах шаардлагатай байна.

### **В. Засгийн газрын зүгээс хангалттай зохицуулалт байдаггүй**

Ус хэрэглэх, ариун цэвэр орчноор хангагдах хүний эрхийг хэрэгжүүлэхэд саад болж буй өөр нэг зүйл нь Монгол Улсын ус, ариун цэврийн салбарын институцийн зохион байгуулалт бүтэц дутмаг байгаа явдал юм. Ус бүхий л салбарт хамаатай байдаг тул Засгийн газрын хэд хэдэн байгууллагууд ус, ариун цэврийн үйлчилгээтэй холбоотой чиг үүрэг, хариуцлага хүлээсэн хэдий ч тодорхой уялдаа холбоогүй байна. Мөн хүний эрхийн тодорхой орчин бүрдээгүй байхад төр, засгийн байгууллагуудын уялдаа нь ус, ариун цэврийн асуудлыг хүний эрхийн суурь агуулга, зарчмуудтай зохицуулж чадахгүй байна. 2010 онд батлагдсан Усны Үндэсний хөтөлбөрт Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Усны Үндэсний хороог үндсэн зохицуулагч байгууллага гэж заасан. Гэвч усны хэрэглээ, ариун цэвэр орчноор хангагдах хүний эрх нь эдгээр байгууллагын чиг үүргээс хальсан асуудал юм.

Миний ойлгосноор, Усны хэрэг эрхлэх газрыг 2012 онд татан буулгаснаар Монгол Улсын иргэдэд ундны ус, ариун цэвэртэй холбоотой үйлчилгээ үзүүлэх асуудлыг хэд хэдэн яамдад хувааж хариуцуулсан байна. Үүний үр дүнд устай холбоотой хүний эрхийн асуудлыг Засгийн газар хэрхэн зохицуулах талаар ойлгомжгүй, тодорхойгүй байдал үүсжээ.

- Ундны ус хангамжийн асуудлаар Байгаль орчин, аялал жуулчлалын яам усны нөөцийг тодорхойлох үүрэгтэй. Гэвч усны нөөцийг тодорхойлсноор ундны усны хүртээмж, усны дэд бүтэц, ариун цэврийн байгууламжийн асуудлыг хангалттай

шийдвэрлэдэггүй. Иймд Барилга, хот байгуулалтын яам дэд бүтцийн бүтээн байгуулалтыг хариуцаж, орон нутгийн түвшинд Ус сувгийн удирдах газар (УСУГ) нийтийн худаг барих асуудлыг хариуцаж байна.

- Усны хүртээмжийн хувьд тухайн дүүрэг, орон нутгийн удирдлага дор УСУГ, Орон сууц, нийтийн аж ахуйг удирдах газар, хувийн хэвшилтэй хамтран өрхүүдэд үйлчилгээ үзүүлдэг бол бэлчээрийн газарт, ялангуяа малчин айл өрхүүдийн ус хангамжийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хүргэх ажлыг хянадаг. Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг усаар хангах асуудлыг хариуцдаг байна.
- Усны чанарын хувьд ус хангамжтай холбоотой усны чанар, эрүүл ахуйн танадалтыг Эрүүл мэндийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран гүйцэтгэх үүрэгтэй; Байгаль орчин, аялал жуулчлал яам нь гадаргын болон гүний усны чанарыг хариуцдаг. Орон нутгийн түвшинд, аймаг дүүргийн захиргааны бүтцэд багтдаг УСУГ нь иргэдэд түгээж байгаа ундны усныхаа чанарыг хянах чиг үүрэгтэй байдаг.
- Үнэ өртгийн хувьд тухайн аймаг дүүрэг, орон нутгийн удирдлага доорх УСУГ-ын саналыг үндэслэн “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл” усны тарифыг тогтоодог; сургууль, эмнэлгийн усны байгууламжийн засвар, үйлчилгээний төсвийг Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын яам болон Эрүүл Мэндийн яам баталж өгдөг; Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нийгмийн халамж шаардлагатай байгаа иргэдийг тодорхойлдог.

Яам тус бүр ус, ариун цэврийн бодлоготой холбоотой тодорхой үүрэг, хариуцлагатай хэдий ч төрийн нэгдсэн бодлого ч байхгүй, Засгийн газарт энэ асуудлын уялдааг хангаж, үр ашигтай хөгжүүлэх бүтэц ч байхгүй. Ундны ус, ариун цэврийн асуудал нь одоогийн байдлаар ус хангамжийн менежментийн асуудалд шингэн замхарсан мэт харагдаж байна. Тодорхой институцийн зохион байгуулалт, төвлөрсөн стратеги байхгүй тул орон нутгийн иргэдэд үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй орон нутгийн засаг захиргааны нэгжүүдэд хүндрэл учруулж байна. Ус, ариун цэврийн асуудлаарх үүрэг, хариуцлагыг төр, засгийн байгууллагууд, институцуудын дунд тархай бутархай байдлаар зохион байгуулснаар хувь хүмүүс хүний эрхээ хамгаалуулах асуудлаар Монгол Улсын Засгийн газраас хариуцлага шаардах боломжгүй болоод байгаа юм.

Монгол Улсад одоо хэрэгжиж байгаа эсвэл ирээдүйд хэрэгжих Засгийн газрын бүтцийн шинэчлэлийн хүрээнд ус, ариун цэврийн асуудлын уялдааг хангах чиг үүргийг аль нэг төрийн захиргааны төв байгууллагад хуваарилах, харин яам тус бүрд энэ асуудлыг хариуцсан ажилтантай байх нь зүйтэй гэж би зөвлөмөөр байна. Ингэж уялдаатай ажиллахдаа хүний эрхийн асуудлыг мөн холбож, үүрэг хүлээсэн байгууллагууд хариуцлага хүлээдэг байхад нь анхаарах шаардлагатай. Дээрх үйлчилгээний хүртээмжийн нэмэгдүүлэхийн тулд Монгол Улсын төв Засгийн газраас бүтээлч хүчин чармайлт гаргаж, хүний эрхийг бүрэн дүүрэн хангах шаардлагатай.

### 3. Ундны ус, ариун цэврийн байгууламж ба хүний эрх

Хүний эрх ба ундны усны аюулгүй байдал, ариун цэврийн байгууламжийг цогц байдлаар хэрэгжүүлснээр Монгол Улс бүх иргэддээ ус хангамж, ариун цэвэр орчныг бий болгох үйлчилгээг ижил тэгш хэмжээнд хүргэж, баян ядуугийн ялгаа, тэгш бус байдлыг арилгахад тус болж, чиглүүлнэ гэдгийг би зориуд тэмдэглэмээр байна. Би зөвлөмж, саналаа тодорхой хэдэн салбарт хүний эрхийг бэхжүүлэх байдлаар илэрхийлье. Бусад салбаруудыг тусгасан илүү дэлгэрэнгүй дүн шинжилгээг би ирэх 9 дүгээр сард Хүний эрхийн зөвлөлд илгээх илтгэлдээ тусгах болно.

#### А. Тогтвортой Хөгжлийн Үзэл Баримтлал 2030

Тогтвортой Хөгжлийн Зорилгуудыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улс үндэснийхээ Тогтвортой хөгжлийн зорилтууд (Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 “ТХҮБ” гэх)–ыг баталж, ТХҮБ–ын хэрэгжилт, хяналтыг ТХЗ–тай уялдуулахаар зорьж байгаа гэж Үндэсний Хөгжлийн Газраас мэдээлж байгаа. ТХҮБ–д орсон ус, ариун цэврийн байгууламжтай холбоотой зорилгуудад Монгол Улсын ТХЗ–уудын дагуу хүлээсэн үүрэг, хариуцлагыг бүрэн тусгаагдаагүй байна гэж би үзэж байна. ТХҮБ–д ус, ариун цэврийн асуудлыг ТХЗ–уудын 6 дахь зорилгын хэсэг болгож оруулсан байдаг ч богино– дунд– болон урт хугацааны зорилго (“зорилт”)–ууд нь хэлбэрийн хувьд ч, агуулгын хувьд ч ТХЗ–оос ангид байна. Энэ хандлага хэвээр байвал 6.1 ба 6.2 дахь зорилтуудын онцлог чанар алдагдаж, салбарын яамдын оролцоог хангахгүй бол энэ хоёр зорилтын хүний эрх, нийгэм–эдийн засгийн чухал үзэл санаа алдагдах юм. ТХЗ–ын гол агуулга нь “Нэг ч хүнийг орхихгүйн төлөө” байдгийг сануулах нь зүйтэй юм. Түүнчлэн ТХЗ–ын ус, ариун цэврийн байгууламжийг хүртээмжтэй болгох тухай 6.1 ба 6.2 дахь зорилтууд нь эрүүл, аюулгүй үйлчилгээг дэлхий даяар хүртээмжтэй түгээхэд оршиж байгаа болохоос биш Мянганы хөгжлийн зорилт (МХЗ)–ын үед хэрэглэгдэж байсан “сайжруулсан үйлчилгээ” гэсэн нэр томъёоноос огт өөр юм.

ТХҮБ–ын ус, ариун цэврийн байгууламжтай холбоотой зорилтуудыг ТХЗ–той уялдуулах, хүний эрхийн өнцгөөс харж хэрэгжүүлэхийг Засгийн газарт зөвлөж байна.

#### В. Усны тариф болон санхүүгийн тогтвортой байдал

Монгол Улсын Засгийн газар усны тариф тооцоолох шинэ аргачлалыг саяхан нэвтрүүлсэн билээ. Засгийн газрын зүгээс усны аюулгүй байдал, ариун цэвэр орчноор хангагдах хүний эрхийг хамгаалах чиглэлээр хүлээсэн үүрэгтэйгээ нийцүүлэн хэд хэдэн туршилтын төсөл хэрэгжүүлж болох тухай саналаа хэлье.

Нэгдүгээрт, хүний эрхийн талаас нь, ус болон ариун цэврийн үйлчилгээний санхүүгийн тогтвортой байдлыг хангахдаа тухайн үйлчилгээг эмзэг бүлгийн хүмүүст хүртээмжтэй (хямд) хүргэх асуудалтай уялдуулан шийдвэрлэх шаардлагатай. Хоёрдугаарт, хүртээмжтэй гэдэг нь зөвхөн хэрэглээний төлбөрийг бага хэмжээнд барих асуудал биш бөгөөд бусад зардлууд, тэр дундаа гэр хорооллын оршин суугчдын хувьд ус, ариун цэврийн үйлчилгээ авахад үүсдэг санхүүгийн дарамтыг бууруулах, мөнгөн бус зардлуудыг тооцох шаардлагатай. Гуравдугаарт, ханган нийлүүлэгчдийн санхүүгийн

тогтвортой байдлыг хангахын тулд дан ганц тариф тогтоох замаар зардлаа нөхөх бүс төрөл бүрийн татвар, шугам сүлжээ, дамжуулалтын шимтгэл зэргийг бодолцох хэрэгтэй. Мөн ихэнх улс орнуудад ус, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээг хамгийн бага хүртдэг, эсвэл огт хүртдэггүй хүмүүс хамгийн өндөр төлбөр төлж байдаг учраас энэхүү үйлчилгээг хямд болгохын тулд бүх хүнд хүрэхүйц үйлчилгээг хөгжүүлэх нь зүйтэй юм. Эцэст нь, ядуу оршин суугчдад хүртээмжтэй тариф тогтоохын тулд арилжааны хэрэглэгчид (аж үйлдвэр, худалдаа, үйлчилгээний байгууллагууд)–ийн хэрэглээний тарифыг нэмэгдүүлж, оршин суугч хоорондын тэтгэмжийн (татаасын) үйлчилгээг хөгжүүлж болох юм. Улсын хэмжээнд усны тарифын шинэчлэл хэрэгжүүлэх тохиолдолд дээрх зарчмыг удирдлага болгохыг зөвлөж байна.

### **С. Усны чанар**

Би айлчлалынхаа үеэр ундны усны чанарын тухай санаа зовнисон хэд хэдэн хүнтэй уулзсан. Эдгээрт уул уурхайн (тэр дундаа бичил уурхайн) үйл ажиллагаа, усны хатуужил, гадаргын усыг хэтрүүлэн ашиглаж, микробиологийн болон химийн бодисоор усыг бохирдуулж байгаа, хувийн хэвшил ус хангамжийн үйлчилгээ үзүүлж байгаа зэргийг дурьдаж болно. Дээрх асуудлыг би эцсийн тайландаа дэлгэрэнгүй байдлаар тусгана.

Урьдчилсан тайландаа би усны чанарын хяналтын асуудалд анхаарлаа хандуулмаар байна. Хүний хэрэглээний усны хувьд МХЕГ Эрүүл мэндийн яамтай хамтран Усны аюулгүй байдлын төлөвлөгөөний дагуу усны чанарын шалгалт явуулж байна. Усны хяналтын дээжийн тоо миний анхаарлыг ихэд татлаа: МХЕГ нь жилд 1,000 дээж цуглуулж хяналт шинжилгээ хийдэг байна. Жилд үүнээс илүү тооны дээж авч байж л ундны усны аюулгүй байдлыг цогц байдлаар хянах боломж бүрдэх ба ингэснээр усны чанарын хяналтын олон улсын зөвлөмжийг хэрэгжүүлэхэд ч тустай болохыг зориуд тодотгон хэлмээр байна. Усны чанарын стандарт хангагдаагүй тохиолдолд нөхцөл байдлыг шуурхай засаж, залруулах үр дүнтэй хэрэгсэл дутмаг байдгийг мөн дурдах хэрэгтэй. Түгшүүртэй мэдээлэл гарах тохиолдолд зөрчлийг арилгуулахаар Шадар сайдад мэдээлэл хүргэж, улмаар үүссэн хүнд нөхцөл байдлыг залруулах урт удаан хугацааны үйл явц эхэлдэг гэж МХЕГ–ын төлөөлөгч надад ярьсан юм.

Усны чанар шалгах газрын хувьд, ус хангамжийг хүргэдэг усны машин болон иргэдийн дунд түгээмэл хэрэглэгддэг ус агуулах сав нь усны чанарт үзүүлэх нөлөөний талаар санаа зовниулсан хэд хэдэн асуудал байв. Энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд Монгол Улсын Засгийн газар МХЕГ–аар дамжуулан нийтийн ус хангамжийн байгууламжуудыг хянахын сацуу хэрэглээний түвшинд усны чанарыг хянах системийг хөгжүүлэхийг зөвлөж байна.

Ундны усны чанарыг хянах явцад хамгийн орчин үеийн стандартыг хэрэглэх нь нэн чухал юм. Одоогийн хэрэглэж буй 2005 онд нэвтрүүлсэн стандартыг ДЭМБ–аас ундны усны чанарын талаар гаргасан зөвлөмжид нийцүүлэн нэн даруй шинэчлэх шаардлага байна. Энэхүү шинэчлэлийг хэрэгжүүлэх үйл явцыг яаравчлан хийж, олон улсын шилдэг стандарт, шинжлэх ухааны ололтыг тусгасан стандартыг нэвтрүүлэхийг би МХЕГ–т зөвлөж байна.

Усны хэрэглээтэй холбоотой хүний эрхийн салшгүй нэгэн хэсэг нь мэдээлэл авах эрх,

тэр дундаа усны чанарын тухай мэдээлэл авах эрх юм. Усны чанарын тухай мэдээллийг иргэдэд ойлгомжтой, тодорхой хэлбэрээр системчлэн хүргэж байхыг би Монгол Улсын Засгийн газарт зөвлөж байна.

#### **D. Ус хангамжийг таслах үйл явц**

Ус хангамжийн үйлчилгээг таслах үйл явцыг тодорхой болгож журамлах шаардлага байгааг онцлон тэмдэглэж байна. Ус хангамж, үйлчилгээний төлбөрөө төлж чадаагүйгээс болж тухайн үйлчилгээг таслах нь хүний эрхийг зөрчиж байгаа гэдгийг зориуд тэмдэглэж байна.

Монгол Улсад усны хангамжийг таслах явдлыг хуулиар хориогүй байдаг. Ус хангамжийн үйлчилгээг тасалсантай холбоотой маргааныг хувь хүн болон УСУГ-тай гэрээлэгч хувийн хэвшил хоорондын маргаан гэж үздэг тул иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэдэг. УСУГ-аас ундны усыг хэрэглэгчдэд хүргэх үйлчилгээг хувийн хэвшил хэрэгжүүлдэг гэсэн үндэслэл хэлдэг. Гэвч хүний эрхийг дээдлэх, хамгаалах, хэрэгжүүлэх үүргийг Засгийн газар, төрийн байгууллагаар дамжуулан төр хариуцдаг гэсэн түгээмэл ойлголтыг сануулах нь зөв. Иймд ус хангамжийн үйлчилгээг төр гуравдагч этгээдэд шилжүүлсэн хэдий ч хариуцлагыг бол төр хүлээх ёстой хэвээр байдаг бөгөөд ус хангамжийг таслах асуудал нь хүний эрхийн асуудалд тооцогдох учиртай.

Ус хангамж, ариун цэвэр орчноор хангагдах хүний эрхийг Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрөөгүй тул Үндсэн хуулийн дагуу ус хангамжийг таслахтай холбоотой маргааныг Үндсэн хуулийн цэц таслах эрхгүй. Энэ нь Монгол Улсын иргэд ус хангамж, ариун цэвэр орчноор хангагдаж чадахгүй байгаа тохиолдолд Монголын шүүхэд хүний эрхээ зөрчүүлсэн асуудлаар хандаж, эрхээ сэргээлгэх боломжгүй байгааг харуулж байна.

\* \* \*

Энэхүү дүгнэлтэд тусгагдсанчлан, бүх иргэддээ баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжийг хүртээмжтэй байдлаар, үйлчилгээний зохих түвшинд аливаа ялгаварлан гадуурхалгүйгээр хүргэх зорилт, алсын харааг Монгол Улсын Засгийн газар хэрэгжүүлсээр байгаа гэдэгт би эргэлзэхгүй байна.

Ус хангамж, ариун цэврийн байгууламжийг харилцан адилгүй байдлаар хүргэх нь хүний эрхийн асуудал гэдгийг дахин дурдаад, Монгол Улс ундны ус, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээг бүх иргэддээ хүргэх хүчин чармайлтаа үргэлжлүүлэн хэрэгжүүлэхдээ хүний эрхийг дээдлэх хэрэгтэйг сануулж байна. Монгол Улсын Засгийн газрын энэхүү үйл хэрэгт нь миний бие дэмжлэг үзүүлж, айлчлалынхаа үеэр хийсэн дүгнэлт, зөвлөмжид тулгуурлан бүтээлч хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлье.



## 10.7 НҮБ–ЫН ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАГЧИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН ТУСГАЙ ИЛТГЭГЧ МИШЕЛЬ ФОРСТЫН 2019 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 30–НААС 5 ДУГААР САРЫН 13–НД МОНГОЛ УЛСАД АЖИЛЛАСАН ТОМИЛОЛТЫН ТАЙЛАН

### 1. Танилцуулга

Сайн байна уу, хүндэт хатагтай ноёд оо,

Юуны өмнө, МУ–ын Засгийн газарт намайг урьж, албан ёсны айлчлалыг зохион байгуулсанд талархал илэрхийлье. Би Монголд 2019 оны 4 дүгээр сарын 30–наас 5 дугаар сарын 13–нд хоёр долоо хоногийн турш ажиллалаа.

Албан томилолтын хугацаанд их ажил амжуулах боломжийг надад олгохын тулд багагүй хүчин чармайлт гаргаж, туйлын сайн хамтран ажилласанд Монгол Улсын Засгийн газарт талархал илэрхийлье. Би Монгол Улсын Ерөнхийлөгч, Гадаад хэргийн яамны сайд, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайд, Ерөнхий Сайдын ахлах зөвлөх нартай уулзлаа. Мөн УИХ–ын дарга болон УИХ–ын Хүний эрхийн дэд хорооны дарга, мөн Ерөнхий Прокурорын газар болон Дээд шүүхийн төлөөлөлтэй уулзлаа. Үүнээс гадна Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Үндэсний дата төв, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Улаанбаатар хотын Хот байгуулалтын асуудал хариуцсан орлогч дарга, Дорноговь аймгийн Айраг сумын засаг дарга болон Зүүнбаян тосгоны дарга нартай уулзав.

Мөн НҮБ–ын агентлагууд, дипломат төлөөлөгчийн газруудын албан хаагчид болон Азийн Хөгжлийн Банкны суурин төлөөлөгчтэй тус тус уулзсан. Үүнээс гадна Orano зэрэг хувийн хэвшлийн компаниудтай уулзсан ба тэдэнд ч мөн хамтран ажилласанд нь талархал илэрхийлье.

Би Улаанбаатар хот болон Дорноговь аймагт ажиллахдаа нийт 100 гаруй Хүний эрхийг хамгаалагчидтай уулзсанаас дөрөвний гурав нь эмэгтэйчүүд байв. Мөн иргэний нийгмийн байгууллагууд, сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд, байгаль хамгаалагчид, хуульчид, үйлдвэрчний эвлэлийнхэн, орон сууцтай байх эрхийг хамгаалагчид, идэвхитэн малчид, шүгэл үлээгчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалагчид, ЛГБТ хүмүүсийг ялгаварлан гадуурхалтын эсрэг тэмцэгсэд зэрэг хүмүүстэй би уулзлаа. Эдгээр эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, хүүхдүүд бол бүгд өөрсдийн болон өрөөлийн эрх, эрх чөлөөг хамгаалагчид мөн. Тиймээс Монгол Улсад тун их эрч хүчтэй, идэвхитэй иргэний нийгэм байдаг гэдгийг би ойлголоо.

Мөн энэ завшааныг ашиглаад Дэлхийн байгаль орчны хамгийн нэр хүндтэй шагнал болох “Голдман” шагналыг хэдхэн хоногийн өмнө хүртсэн Баяржаргал Агваанцэрэнд баяр хүргэе. Надтай ярилцах хүсэлтэй олон хүн байсан боловч тэд надтай уулзсныхаа төлөө дайралт давшилтанд орохоос эмээж байгаа тул больсон тухай би сонслоо. Олон эх сурвалжаас бичгээр ирүүлсэн мэдээллийг авсан нь газар дээрх нөхцөл байдлыг сайн ойлгоход, мөн Хүний эрхийн хамгаалагчдын үйл ажиллагаа явуулж буй ерөнхий нөхцөл байдлыг ойлгоход тус дэм боллоо. Надтай биечлэн уулзаж мэдээлэл, зөвлөмж өгсөн, үзэл бодлоо илэрхийлсэн хүн болгонд би гүнээ талархаж байна.

Энэхүү ажлын айлчлалыг зохион байгуулахад гар бие оролцсон хүн бүхэнд, ялангуяа НҮБ-ын Суурин зохицуулагчийн ажлын албанд баярлаж байгаагаа илэрхийлье.

Миний айлчлалын гол зорилго бол Монгол Улс нь олон улсын Хүний эрхийн тухай хууль, стандарт, ялангуяа өнгөрсөн онд 20 жилийн ой нь болсон “НҮБ-ын Хүний Эрхийг Хамгаалагчдын Тунхаглал”-ын дагуу Хүний эрхийг хамгаалагчдад үйл ажиллагаа явуулахад нь аюулгүй, таатай орчинг бүрдүүлэх үндсэн суурийг бүрдүүлсэн эсэхэд үнэлгээ өгөх явдал юм. Үнэлгээг хамтын ажиллагаа, харилцан ярианд тулгуурлаж хийдэг болно. Өөрөөр хэлбэл, энэхүү айлчлал хийснээр би Монголд Хүний эрхийг хамгаалагчид айх аюулгүй, бүхий л талаар дэмжигдэж байна уу гэсэн асуултад хариулт өгөхийг зорьсон юм.

Олон улсын Хүний эрхийн тухай хуулийн дагуу, төр нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих үүрэг хүлээдэг билээ. Үүнд хүн бүр, ганцаараа буюу бусадтай хамтарч, хүний эрхийг хамгаалах болон биелүүлэхийн төлөө зүтгэх эрхийг баталгаажуулах явдал орно. Өөрөөр хэлбэл, бидний хэнд ч, хүний бүх эрхийг хамгаалах эрх байдаг гэсэн үг юм.

Үнэлгээ хийх явцад Хүний эрхийг хамгаалагчдын хувьд аюулгүй, таатай орчин бүрдсэн байна уу гэдэг асуултанд гол анхаарлыг хандуулсан юм. Үүнд: хөхиүлэн дэмжсэн хууль эрх зүйн орчин болон институцийн бүтэц; шүүхэд хандах боломж; хараат бус бөгөөд хүчтэй үндэсний хүний эрхийг хамгаалах байгууллагууд; эрсдлийн бүлгүүдэд онцгой анхаарал хандуулсан, үр дүнтэй хамгаалалтын бодлого, механизм; жендэрийн мэдрэмжтэй арга хандлага; Хүний эрхийг хамгаагчдын ажлыг хүндэлж, дэмжлэг үзүүлдэг төрийн бус оролцогчид; эрч хүчтэй бөгөөд хүчирхэг Хүний эрхийг хамгаагчид байгаа эсэхийг олж тогтоодог юм.

НҮБ-д Хүний эрхийг хамгаагчдыг өргөн хүрээнд дэлгэрэнгүй тодорхойлсон байдаг нь 1998 оны 12-р сард батлагдсан НҮБ-ын Хүний Эрхийг Хамгаалагчдын Тунхаглалд багтсан билээ. Айлчлалынхаа явцад би олон тохиолдолд завшааныг ашиглан энэхүү тодорхойлолтыг талуудад танилцуулж байв. Ганцаар болон бусадтай эвлэлдэн нэгдэж, үндэсний болон олон улсын түвшинд хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, биелүүлэхийн төлөө тайван замаар ажилааж байгаа хүмүүсийг Хүний эрхийг хамгаалагч гэнэ.

Тэд бол авилга, шударга бус байдал, ялгаварлан гадуурхах явдал, байгаль сүйтгэн доройтуулах үйлдлийн эсрэг дүү хоолойгоо гаргадаг, мөн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, чөлөөтэй зорчих болон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, шударга ёс ба эрэгтэй эмэгтэйчүүдийн тэгш эрх болон бусал хүний эрхийн төлөө хүчин зүтгэдэг хүмүүс юм. Хүний эрхийг хамгаалагчид байхын тулд тэд заавал аль нэг бүртгэлтэй байгууллагад харьяалагдах албагүй. Тэд бол хүний эрхийн түгээмэл байдалд итгэдэг, хүний эрхийг хамгаалахын төлөө зүтгэдэг жирийн нэгэн эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, хүүхдүүд юм. Хүний эрхийг хамгаалагчид бол өөрчлөлт шинэчлэлийг авчирдаг, ардчиллыг эрхэмлэж түүнийг нээлттэй байхыг шаарддаг, олон ургалч, идэвхитэй оролцдог хүмүүс юм.

Энэ тодорхойлолтыг Монголд тэр бүр сайн мэддэггүй, ойлгодоггүй бололтой. Төрийн албан хаагчид, Хүний эрхийг хамгаалагчид өөрсдөө, олон нийт бүхэлдээ Хүний эрхийг хамгаалагч гэж хэнийг хэлэх вэ гэдгийг сайн ойлгодоггүйг би ажиглав. Засгийн

газар болон ХЭҮК нь энэ ойлголтыг сурталчлан таниулах, НҮБ-ын Хүний Эрхийг Хамгаалагчдын Тунхаглалыг олон нийтэд түгээхэд анхааран ажиллахыг зөвлөж байна. Мөн олон нийтийн кампанит ажил зохион байгуулах, сургалт хийх, мэдэгдэл гаргах замаар Хүний эрхийг хамгаалагчдын ажлыг хууль ёсны бөгөөд чухал болохыг олон нийтийн өмнө хүлээн зөвшөөрөх хэрэгтэй байна.

Төр, нийгмийн зүтгэлтэн С.Зоригийн амь насыг хороосон хэрэгт холбогдсон хоёр хүнийг эрүүдэн шүүсэн тухай нууц бичлэгийг ил гаргасан явдлаас хойш 2 долоо хоногийн дараа би Монголд ирсэн юм билээ. Олон нийтийг цочроосон энэхүү чухал үйл явдал нь хууль зөрчигдөж байгаа тухай зоригтойгоор ярьдаг хүмүүсийн нийгэмд гүйцэтгэж буй чухал үүргийг ойлгуулж, тэдгээр хүмүүсийн хамгаалах шаардлага байгааг харууллаа. Энэ явдлыг улс төрийн ашиг сонирхолд хэрэглэж хэрхэвч болохгүй. УИХ-ын даргатай уулзаж байхад тэрээр ойрын үед хүний эрхийн асуудлаар, ялангуяа хүүхдийн эрхийн асуудлаар нийтийн сонсгол зохион байгуулахаар төлөвлөж байгаа тухай надад танилцуулахад би их олзуурхан дэмжсэн юм.

Би бол НҮБ-ын ажилтан биш, миний бие зөвхөн сайн дурын үндсэн дээр ажиллаж, хийсэн ажлынхаа төлөө цалин хөлс авдаггүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Хараат бус шинжээчийн хувьд би зөвхөн мэргэжилтний болон хувь хүнийхаа хувьд дүгнэлт гаргаж, тайлангаа НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлд болон Ерөнхий Ассамблейд шууд танилцуулдаг юм.

Өнөөдөр би зарим асуудлаар өөрийн гаргасан урдчилсан ажиглалт, зөвлөмжийг танилцуулах болно. Улмаар албан айлчлалын явцад цуглуулсан баримт, мэдээллийг бүрэн судалж нягтлан боловсруулсны эцэст дэлгэрэнгүй тайлангаа боловсруулах болно. Эцсийн тайлангаа би 2020 оны 3-р сард Швейцарийн Женев хотод болох НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлд танилцуулах юм.

## **2. Ерөнхий үнэлгээ: Монгол Улсад Хүний эрхийг хамгаалагчдын хувьд аюулгүй, таатай орчин байна уу?**

Монголын Хүний эрхийг хамгаалагчид нь шударга ёс, жендэрийн тэгш байдал, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, байгаль хамгаалал, нийгмийн, эдийн засгийн, соёлын эрх зэрэг олон салбарт идэвхитэй ажилладаг.

Монголд хүний эрхийг хамгаалагчдын эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах заалтуудыг агуулсан олон сайн хуулиуд байдаг. Гэхдээ бодит амьдрал дээр эдгээр хуулиудын хэрэгжилт сул байдаг нь Хүний эрхийг хамгаалагчдын ажлыг хүндрүүлж байна.

Үнээс гадна, сүүлийн үед батлагдсан хуулийн нэмэлт өөрчлөлтүүд нь эрх зүйд захирагдах ёсонд ухралт гаргаж, иргэний нийгмийн орон зайг хумих эрсдэл дагуулж байгаа нь миний анхаарлыг татав.

Засгийн газар, иргэний нийгмийн байгууллагууд болон бусад талуудаас авсан мэдээллийг сайтар тунгааж үзээд, Монгол Улс нь Хүний эрхийг хамгаалагчдын хувьд харьцангуй аюулгүй орон юм гэж би дүгнэж байна. Хүний эрхийг хамгаалагчдын эсрэг халдлага гарч, шахалт дарамт ирж байсан зарим тохиолдлууд бүртгэгдсэн байдаг ч, Хүний эрхийг хамгаалагчдын эсрэг зохион байгуулалттай халдлага үйлдэх явдал Монголд алга гэж би үзэж байна.

Монголд харьцангуй аюулгүй орчин байгаа хэдий ч, Хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагааг хөхиүлэн дэмждэг, тэдэнд боломж олгодог, бүрэн эрхийг нь эдлүүлдэг таатай орчин бүрдээгүй байна. Тэдний ажлыг гутаан доромжлох, шахалт дарамт үзүүлэх, гэмт хэрэгт гүтгэх, нийгмийн сүлжээгээр үзэн ядах үг хэллэгээр дайрч давшлах, хүний эрхийг хамгаалагч гэж хэн болох талаар ойлгохгүй байх, мэдээлэл авах болон шийдвэр гаргах үйл явцад оролцох эрхийг нь хязгаарлах зэрэг явдал нь Хүний эрхийг хамгаалагчдад хүндрэл учруулж байна. Үүнээс гадна, хэд хэдэн хуульд орсон аюултай нэмэлт өөрчлөлтүүд нь улс төрийн эрхийг цөөн хүний гарт төвлөрүүлэх чиг хандлага бий болгож байгаа нь ноцтой хэрэг юм. Энэ нь Хүний эрхийг хамгаалагчдын дунд айдас төрүүлж байгаа тул тэдний заримыг нь цаашид хүний эрхийг хамгаалах ажлаа хийхээс татгалзахад хүргэж байна. Эдгээр асуудлыг зөв зүйтэй шийдвэрлэхгүй бол урт хугацаандаа хүний эрхээ эдлэхэд сөрөгөөр нөлөөлж болзошгүй юм.

Монголд ажиллаж байх хугацаандаа Хүний эрхийг хамгаалагчид, үүн дотор бэлгийн цөөнх, хүүхдийн эрхийг хамгаалдаг хүүхдүүд хүртэл ялгаварлан гадуурхагддаг, гутаан доромжлогддог, гүтгэгддэг, шахалт дарамтанд байдаг талаар би олонтаа сонслоо. Байгаль хамгаалагчид, авилгалын хэргүүд дээр ажилладаг эрэн сурвалжлах сэтгүүлчдийг айлган сүрдүүлдэг, шахалт дарамт үзүүлдэг тухай ч сонслоо. Тэдгээр хүмүүсийн зарим нь амь насаа алдсан ч, үхлийн шалтгааныг нарийвчлан судалж эцэслэн тогтоогоогүй байна.

Авилгал, байгаль орчны доройтол зэрэг эмзэг асуудлыг хөндөж ярьсны төлөө Хүний эрхийг хамгаалагчдыг айлган сүрдүүлдэг, нэр төрийг нь гутаадаг, мөн тэдний гэр бүлийн гишүүдийг ч нийгмийн болон эдийн засгийн элдэв шахалт, дарамтанд оруулдаг, жишээ нь ажилд орох, сургалтын тэтгэлэг авах, төсөлд хамрагдахад тэдэнд хүндрэлтэй байдаг тухай би сонслоо. Монголын хүн ам цөөн, ялангуяа орон нутагт хүмүүс нэг нэгнийгээ сайн таньдаг учраас иймэрхүү дарамт шахалт нь сэрдэлт, айдсыг дагуулдаг тул болж бүтэхгүй байгаа зүйлийг ил гаргах хүсэлтэй Хүний эрхийг хамгаалагчдын зориг мохох эрсдэл байна.

Хүний эрхийг хамгаалагчийн тухай хуулийг батлах явдал нь Хүний эрхийг хамгаалагчдын хийж буй чухал бөгөөд хууль ёсны ажлыг дэмжих, хүлээн зөвшөөрөх, мөн тэдний эсрэг халдлага үйлдэж буй этгээдүүдэд шийтгэл оноох чухал бөгөөд тодорхой алхам болно. Хүний эрхийг хамгаалагчид ажлаа чөлөөтэй, хараат бүс байдлаар хийдэг болохын тулд дэмжих таатай орчинг бий болгох хэрэгтэй.

МУ-ын Засгийн газар Хүний эрхийг хамгаалагчдын тухай хууль батлахаар ажиллаж байгааг сонсоход таатай байлаа. Харамсалтай нь Хууль зүй, дотоод хэргийн яамнаас энэхүү хуулийн төслийг батлуулахаас цаараглаж байгаа тухай надад бас дуулгасан юм. Одоогийн байдлаар Ази, Номхон далайн бүс нутагт ийм хууль баталсан улс орон хараахан алга. Харин Монгол Улс Хүний эрхийг хамгаалагчдын тухай хууль баталбал бүс нутагтаа хүний эрхийг дээдлэгч, манлайлагч улс болох боломж бий. Ази, Номхон далайн бүсийн зарим орны Хүний эрхийг хамгаалагчдын өмнө тулгамддаг сорил Монголд үгүй ч, Монгол Улсад хүний эрхийг хамгаалж, сурталчилдаг хүмүүсийнхээ эрхийг хамгаалах сайн хууль батлагдвал нийгэмд тэдний гүйцэтгэж буй чухал үүргийг хүлээн зөвшөөрүүлэх явдалд нэлээд ач холбогдолтой байх болно.

## **А. Эрх зүй ба институцийн хүрээ**

### **Эрх зүйн хүрээ ба институцийн хөгжил**

1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуульд тэгш эрх болон үл ялгаварлах зарчмыг баталгаажуулсан (14–р зүйл) бол түүний 16–р зүйлд төрийн хэрэгт оролцох эрх, нам болон олон нийтийн бусад байгууллага байгуулах, чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрх, төрийн байгууллагад өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрх, халдашгүй чөлөөтэй байх эрх, шударга шүүхээр шүүлгэх эрх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө, мэдээлэл хайх, хүлээн авах эрх болон чөлөөтэй зорчих эрх гэх зэрэг хүний эрхийг хамгаалагчдад нэн шаардлагатай хэд хэдэн суурь эрх, эрх чөлөөг мөн жагсаасан байна.

Монгол Улс дахь хүний эрхийн хамгаалагчдын ажлыг хамарсан хууль тогтоомж нь олон улсын хэм хэмжээтэй сайтар нийцэж байна. Гэсэн хэдий ч олон сайн хуулийг үр дүнтэй хэрэгжүүлдэггүйн дээр илүү хатуу хууль боловсруулж буй болохыг надтай уулзсан зарим хүмүүс онцолсон. Монгол Улсын нэр хүнд олон улсад өндөр боловч одоо уг асуудлаар холимог дохио өгч байна. Дөрвөн асуудалд миний санаа илүү зовж байна.

Эхний асуудал нь хүний эрхийн төрийн бус байгууллага байгуулах, үйл ажиллагаа явуулах харилцааг зохицуулах хууль юм. 1997 оноос хойш Монгол Улс олон улсын хэм хэмжээнд нийцсэн хуультай болсон. Хэдий тийм боловч, УИХ–ын түвшинд мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх нэрийн дор энэхүү хуулийг шинэчлэх санаачлага явж байгаа нь гадаадын санхүүжилтийг хязгаарлах олон улсын чиг хандлагыг дагаж байна. Иргэний нийгмийн байгууллагууд энэхүү хуулиас үүдэж болох бүртгэл болоод гадаадын санхүүжилт авахтай холбоотой бэрхшээлүүд гарна хэмээн санаа зовниж буйгаа илэрхийлсэн. Түүнчлэн төрийн албан хаагчдын зүгээс гадаадын санхүүжилттэй байгууллагууд үндэсний ашиг сонирхолд нийцэхгүй хэмээх санаа агуулсан хэд хэдэн үндсэрхэг мэдэгдлийг тэд онцолсон. Засгийн газрын зүгээс иргэний нийгмийн байгууллага, Хүний эрхийн Үндэсний комисс, олон улсын мэргэжилтэн болон стратегийн зөвлөгөө өгөх боломжтой бусад этгээдтэй цаашид хамтран ажиллаж, улмаар уг хуулийн эцсийн төслийг олон улсын хэм хэмжээтэй нийцүүлэхийг би уриалж байна. Миний зүгээс үүгээр зогсолгүй Засгийн газарт энэ чиглэлээр туслалцаа үзүүлэхэд бэлэн байна.

Хоёр дахь асуудал нь шүүхийн хараат бус байдалтай холбоотой юм. Энэхүү томилгоот ажил болохоос хэдэн долоо хоногийн өмнө УИХ–аас ээлжит бус чуулган зарлаж, нээлттэй сонсгол эсхүл олон нийтийн хэлэлцүүлэг хийлгүйгээр Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Прокурорын байгууллагын тухай хууль болон Авлигын эсрэг хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан болно. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нь тэдгээр нэмэлт өөрчлөлтөөр дээд шүүгч, прокурорын газар болон Авлигатай тэмцэх газрын дарга нарыг огцруулах зөвлөмж гаргах эрхтэй болсон. Хууль тогтоомжоо ийнхүү огцом өөрчилсөн нь эрх мэдлийн хуваарилалтыг эрс эвдэж, шүүхийн хараат бус байдлыг аюултайгаар бууруулж, харилцан хяналт тавих концепцийг эмтрүүлэхээс гадна авлига болон хуулийн хариуцлагаас бултахтай тэмцэх шүүхийн чадавхийг хязгаарлаж буй болно. Хамгаалагч нарын мэдүүлсэнчилэн энэхүү шинэчлэл нь айдас хүйдэс бий болгож, авлига, ялгаварлан гадуурхалтын эсрэг дуугарч, шударга ёсыг уриалан дуудаж буй хүмүүст тод анхааруулга

өгч буйн зэрэгцээ хамгаалагч нарын орон зайг бууруулахад хувь нэмрээ оруулж байна.

Миний айлчлалын үед буюу 5-р сарын 9-нд УИХ-аас Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан. Энэхүү шийдвэрийн дагуу захиргааны шүүх Засгийн газрын зүгээс УИХ-ын тогтоол, удирдамжид үндэслэн гаргасан аливаа шийдвэрийг хянах боломжгүй болж буй юм. Хүний эрхийн байгууллага олон нийтийн ашиг сонирхлын асуудлаар шүүхэд хандах боломжтойг үнэлж байгаа боловч ийм шүүхийн маргаан эдгээр нэмэлт өөрчлөлтийг баталснаар бүх утгаа алдана гэж гүнээ санаа зовниж буй болно.

Түүнчлэн, сүүлийн хоёр асуудал нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө эдлэхтэй холбоотой юм. Юуны өмнө би Монгол Улсад шинэ Эрүүгийн хуульдаа гүтгэлгийг гэмт хэргээс хассанд баяр хүргэж байна. Гэхдээ гэмт хэрэгт тооцохоор дахин өөрчилж болзошгүй гэж би сонссон. Түүнчлэн, миний бие 2017 оны 7-р сараас хойш хүний нэр төр эсхүл хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон гэх худал мэдээлэл тараавал Зөрчлийн тухай хуулийн 6.21-ийн дагуу шийтгэхээр байгааг шүүмжлэлийн эсрэг ашиглах болсныг олж мэдлээ. Хүний эрхийн байгууллагуудын өгсөн мэдээллээр 2017 оны 7-р сараас 2018 оны 3-р сарын хугацаанд 230 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилчид болон нийгмийн сүлжээний хэрэглэгчид энэхүү зүйлийн дагуу мөрдөн шалгагдаж, ихээхэн хэмжээний мөнгөн торгууль амссан байна. Хүний эрхийг хамгаалагчид болон сэтгүүлчид энэхүү зөрчлийн тодорхойлолт нь тодорхой бус, хэт өргөн хүрээнд томъёологдсон тул сэтгүүлчид, хүний эрхийг хамгаалагчдыг намжаах зорилгоор ашиглах эсхүл гол дуу хоолойг барих (өөртөө цензур тавих) нөлөө үзүүлэх боломжтой хэмээн санаа зовниж буйгаа илэрхийлсэн. Нэн ялангуяа, үүнд торгуульд унах эрсдэл нь эдийн засгийн цензур болж буйг тодотгосон.

Түүнчлэн, 2014 оноос хойш хэвлэл мэдээллийн вэб хуудсууд сэтгэгдэл үлдээж буй хэрэглэгчдийн IP хаягийг сэтгэгдэлтэй хамт ил тавихыг шаардсан журам үйлчилж байгаад санаа зовниж байна. Хэрэв батлагдвал нийгмийн сүлжээ ашиглагчид регистрийн дугаараар баталгаажуулахыг шаардах хуулийн төсөл одоо явагдаж буйд бүр илүү санаа зовниж байна. Хэрэв батлагдвал, эдгээр шаардлага нь хэрэглэгчдийн хувь хүний нууц, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхийг зөрчиж, иргэний нийгмийн чөлөөт үйл ажиллагааг боомилоход хүргэнэ.

### **Зөвлөмж**

- Төрийн бус байгууллагын тухай хуульд оруулах аливаа өөрчлөлтийг олон улсын хэм хэмжээтэй нийцүүлэх. Нэмэлт өөрчлөлт нь хүний эрхийг хамгаалагчид болон хүний эрхийн байгууллагуудын ажлыг хязгаарлах бус ажлаа явуулах боломжоор хангахад чиглүүлэх.
- Шүүхийн хараат бус байдал, прокурорын байгууллагын бие даасан байдал болоод эрх мэдлийн хуваарилалтыг сэргээх.
- Интернет болон бусад бүх орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй холбоотой үндэсний хууль тогтоомжоо Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакттай нийцүүлэх. Төрийн бодлого болон бизнесийн үйл ажиллагааг шүүмжилснээр мөрдлөг, дарамт эсхүл хүчирхийлэл амсдаггүй байх нөхцөлөөр хангах.

- НҮБ–ын Хүний эрхийн дээд комиссарын газар, НҮБХХ, Дэлхийн Банк болон Азийн Хөгжлийн Банкнийг урьж, шүүх болон прокурорын байгууллагын хуульд саяхан оруулсан өөрчлөлтөө дахин нухацтай авч үзэх, шүүхийн хараат бус байдал, прокурорын бие даасан байдал болон эрх мэдлийн хуваарилалтын талаарх олон улсын хэм хэмжээнд нийцсэн хууль тогтоомжтой болох чиглэлээр үндэсний байгууллагуудыг дэмжих.

### **Хууль тогтоомжийн практик**

#### **Авлига ба хуулийн хариуцлагаас гадуур үлдэх**

Монголд ажиллах хугацаандаа авсан мэдээллийн дагуу Монголд нийт 8,000 албан ёсны бүртгэлтэй ТББ байгаагаас 90 гаруй нь хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Хуульч, сэтгүүлч Тэд бүгд нийгэмд чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэсэн хэдий ч, зарим практик тэдний ажилд тээг болж байна. Томилгоот ажлын хүрээнд иргэний нийгмийн байгууллагууд авлига бүх түвшинд байгаа гэх нь хамгийн том санаа зовниж буй асуудал болж байна. Сүүлийн хэдэн сард мянга мянган иргэд санхүүгийн болоод авлигын скандалд холбогдсон төрийн албан хаагч нарт албан ёсны мөрдлөг явуулахыг шаардан гудамжинд жагссан. Бусармаг явдлыг ил болгосон шүгэл үлээгчид болон хүний эрхийг хамгаалагчид нарт цагдаа, тагнуулын байгууллага гэх зэргээс ихээхэн дарамт ирсэн гэж мэдэгдсэн. Эдийн засгийн өсөлтийг хангах, тогтвортой хөгжлийг цогцлоох болоод хүний эрхийг хэрэгжүүлэхэд сайн засаглал эхлээд бүрдсэн байх ёстой гэж би гүнээ итгэдэг.

Зарим хүний эрхийг хамгаалагчид болон хүний эрхийн байгууллага эдийн засаг, улс төр эсхүл уул уурхайтай холбогдолтой асуудлаар ажилладаг хүмүүсийн үхэл, мөн тэдгээрт ирэх заналхийлэл, хүчирхийллийн хэргийг үр дүнтэй мөрдөөгүй гэж мэдэгдсэн. Энэ нь хүний эрхийг хамгаалагч нарт эрхээ сэргээх, хүний эрхийн зөрчлийг зохих ёсоор арилгуулах эрхийг доройтуулахаас гадна өөрөө өөртөө цензур тавихад хувь нэмэр оруулсан. Эдгээр асуудлаар ажиллах нь эдийн засаг эсхүл нийгмийн шийтгэл хүлээхэд хүргэнэ гэсэн нийтлэг айдас байгаа бөгөөд эрхийн манаач байгууллагуудыг хяналтдаа авсан саяны хуулийн шинэчлэл үүнийг бүр дордуулж буй болно. Хуулийн хариуцлагаас гадуур үлдэх байдал нь хохирогч нарт маш муу дохио өгч буй бөгөөд хүний эрхийн төлөө зогсох аливаа этгээдийг айлгаж, тогтооход ноцтой нөлөө үзүүлэхийн зэрэгцээ хүний эрхийг хамгаалагчдын эсрэг шинэ дайралт, хүчирхийлэл үйлдэхийг турхирах юм.

#### **Мэдээлэл авах эрх**

Бидний авсан мэдээллийн дагуу, 2011 онд батлагдсан Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулиар олон хамгаалалт бүхий заалтууд нэвтрүүлсэн хэдий ч газрын болоод байгаль орчны эрхийг хамгаалагчид, эрэн сурвалжлагч сэтгүүлчид болон шүгэл үлээгчдэд лицензийн мэдээлэл, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ болон байгаль орчны төлөвлөгөө гэх зэрэг уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл авахад хүндрэл учирч байна. Ихэнх тохиолдолд, компаниуд нөлөөлөлд өртсөн иргэдтэй зөв зохистой харьцахаасаа илүү төслөө зарах байдлаар явж ирсэн. Орон нутгийн иргэдийн уулзалтаар хүний эрх болоод байгаль орчны эрсдэлийг ил болгосны дараа

зарим уурхайн үйл ажиллагааг зогсоосон болохыг би онцолж байна. Орон нутгийн засаг захиргааны зүгээс малчид болон компани хоорондын харилцааг нэн ялангуяа уул уурхайн төслөөс хүний эрхэд үзүүлэх сорилтуудын хүрээнд зохицуулахад бэрхшээлтэй байгаагаа илтгэсэн. Уул уурхайн төслийг дэмжих, мөн эсэргүүцэх иргэдийн дундах санал зөрөлдөөн орон нутгийг хоёр талд хувааж буй нь цаашлаад хүний эрхийн зөрчил үүсгэж магадгүй байна.

### **Тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөө**

Тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөг хуулиар хамгаалсан боловч зарим асуудал байгаа нь миний анхааралд өртсөн болно. Иргэд жагсаал цуглаан хийхийн тулд цуглах цаг хугацаа, байршлаа нутгийн засаг захиргаанд зөвхөн мэдэгдэх хэрэгтэй. Гэсэн хэдий ч, практик дээр ЛГБТ хамгаалагчид, хүүхдийн эрхийн хамгаалагчид болон үйлдвэрчний эвлэлийнхэн гэх зэрэг зарим бүлгийн хамгаалагчдад саад бэрхшээл учирч байна. Үнэндээ, жагсаал хийх талаар мэдэгдэхэд тэр өдөр өөр цуглаан эсхүл олон нийтийн арга хэмжээ төлөвлөсөн тул өөр өдөр товлон хүсэлт тавьдаг байна. Зарим тохиолдолд, эрх бүхий байгууллагууд нь ёс зүйгүй гэх үндэслэлээр тухайн арга хэмжээг бүртгэхээс татгалзсан байна. Нийслэлийн удирдлага ЛГБТ иргэдэд Тэгш эрх болон Бахархлын өдрийн хүрээнд Сүхбаатарын талбайг ашиглуулахаас сүүлийн хэдэн жил удаа дараа татгалзсан байна.

### **Зөвлөмж**

- Хүний эрхийн хамгаалагчдын эсрэг зөрчил, хүчирхийлэл болон дайралтын хэргийг үр дүнтэй мөрдөж, яллахаас гадна эрхийг сэргээх.
- Аян явуулах болоод өндөр албан тушаалтнуудаар мэдэгдэл гаргуулах замаар хүний эрхийг хамгаалагчдын Монгол Улсад гүйцэтгэж буй үүрэг ролийн ач холбогдол ба хууль ёсны эрхийг олон нийтээр хүлээн зөвшөөрүүлэх. Хамгаалагчдыг айлган сүрдүүлэг, мөрдлөг хавчлага болон хүчирхийллээс ангид байлгаж, төрийн бодлого, хууль тогтоомжийн шийдвэр гаргах үйл явцад оролцуулах.
- НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхгийг төрийн албан хаагчдын дунд түгээж, тэдэнд хүний эрхийг хамгаалагчид хэн болох, нийгэмд ямар хувь нэмэр оруулдаг талаар ойлгуулах.
- Тайван жагсаал цуглаан хийх эрхийн хувьд олон улсын хэм хэмжээний дагуу үндэсний хууль тогтоомжоо зохих ёсоор хүндлэх. Хөдөлмөрийн хуульд оруулах аливаа өөрчлөлтөөр ажил хаялт зарлах эрхийг хязгаарлахгүй байх бөгөөд энэхүү эрхийг хамтын хэлэлцээр хэрэгжихгүй байх нөхцөлд баталгаажуулсан байх шаардлагатай юм.

### **Б. Хүний эрхийг хамгаалах үндэсний байгууллагууд**

#### **Монгол улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс**

Энэхүү томилолтын хугацаанд би Монгол улсын Хүний эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК)-ын дарга ноён Ж.Бямбадоржтой уулзсан бөгөөд тэрээр өөрийн байгууллагын



хийж гүйцэтгэдэг ажлыг бүхэлд нь тайлбарлаж танилцуулсан. Уулзаж ярилцсан хүний эрхийн хамгаалагчид бүгдээрээ ХЭҮК нь улс оронд тулгамдаад буй асуудлуудыг сайтар мэддэг бөгөөд орон нутагт тогтмол ирж тэдэнтэй уулзаж, ажил байдалтай нь танилцдаг гэж хэлж байлаа. Гэхдээ ХЭҮК-ын үйл ажиллагааны санхүүжилт, хөрөнгө нөөц хомс буюу хязгаарлагдмал, мөн нийслэл хотоос гадна ажиллаж буй ажилтнуудын хамгаалалтыг илүү сайжруулах шаардлага байна.

Гарсан тохиолдол бүрт хүний эрхийг хамгаалах үндэсний байгууллагууд нь Төрийн институцын бүтцийн бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд хүний эрхийн хамгаалагчдын ажиллах аюулгүй, таатай орчинг бүрдүүлэхэд гол үүрэг гүйцэтгэж ирснийг би санаж байна. Парисын Зарчмыг дагаж мөрддөг хүний эрхийн үндэсний байгууллага нь Засгийн газарт хүний эрхийг хамгаалах үүрэг хариуцлагын талаар заавар, зөвлөмж хүргүүлэх, дотоодын хууль тогтоомжид олон улсын зарчим, стандартуудыг зохих ёсоор тусган оруулж, Хүний эрхийн хамгаалагчдын тухайд баримтлах бодлого гэх мэт төрийн бодлогод нэгтгэх нөхцлийг хангахад онцгой байр суурь эзэлдэг. Нотолгооноос харахад хүний эрхийн үндэсний байгууллагуудын бүрэн эрхэд хувь хүмүүсийн гомдлын мөрөөр судалж шалгах, гомдол гаргагчдыг үр дүнтэй хамгаалалтаар хангах чадамж, хангалттай хөрөнгийн эх үүсвэр ба түүнийг захиран зарцуулах эрх мэдэл багтсанаар тухайн улсын шүүхийн тогтолцоо нь хүний эрхийн хамгаалагчдын эсрэг үйлдэгдсэн зөрчлийн хэргийг шийдвэрлэх чадваргүй буюу шийдвэрлэхийг хүсэхгүй байх тохиолдолд тэдгээр байгууллагууд тэргүүлэх үүрэг гүйцэтгэдэг байна.

### **Зөвлөмж**

- Парисын Зарчмыг бүрэн дагаж мөрдөх нөхцлийг хангахын тулд Монгол улсын ХЭҮК-ын эрх зүйн орчинг баталгаажуулах.
- Хүн хүчний болон санхүүгийн нөөцийг нь сайжруулах замаар ХЭҮК-ын хараат бус, бие даасан байдал, чадавхыг бэхжүүлэх.

### **Хүний эрхийг хамгаалах үндэсний механизм**

Засгийн газрын зүгээс Хүний эрхийг хамгаалагчдын эрх зүйн байдлын тухай хуультай болох улс төрийн үүрэг амлалт авсанд баяртай байна. Түүнчлэн энэхүү хуулийн төслийг боловсруулах ажилд хүний эрхийн хамгаалагчид, байгууллагууд оролцсонд талархаж байна. Гэвч Засгийн газрын 2019 оны 2 дугаар сарын хуралдаанаар хуулийн төсөлд тусгасан хүний эрхийн хамгаалагчдын хамгаалалтын механизм нь төрийн үйлчилгээний үүрэг функцэд давхардал үүсгэж, боловсон хүчин ба хөрөнгө зарцуулалтыг шаардлагагүйгээр өсгөхөд хүргэнэ гэсэн үндэслэлээр уг хуулийн төслийг дэмжээгүй нь харамсалтай. Засгийн газраас одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хуулиудаар хүний эрхийн хамгаалагчдын асуудлыг зохицуулж болно хэмээн татгалзсан үндэслэлээ тайлбарласан байна.

Өмнө дурдсанчлан, энэхүү хуулийг хэрэгжүүлэх нь бүс нутгийн түвшинд хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалах чиглэлд маш чухал алхам болох юм. Мэдээж хэрэг уг хууль болон түүний хүрээнд бүрэлдүүлэх механизм нь Монгол улсын өвөрмөц нөхцөл байдалд нийцсэн байх, хүний эрхийн хамгаалагчдын ажил үүргийг хүлээн зөвшөөрч, дэмжиж,

ажиллах нөхцлийг сайжруулах чиглэлд авч хэрэгжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээ, стратегиудад анхаарах хэрэгтэй.

Надад Засгийн газраас, ХЭҮК болон иргэний нийгмийн төлөөллүүдийн хамтран боловсруулсан бичвэртэй танилцах боломж олдсон юм. Тэрхүү бичвэрт ийм хэлбэрийн хууль тогтоомжийн нийгэмд гүйцэтгэж болох эерэг үүрэг оролцоонд итгэх итгэлийг надад төрүүлсэн олон тооны хамгаалах заалтууд багтсан байна. Хуулийн төслийг илүү боловсронгуй болгоход үнэтэй хувь нэмэр оруулна гэж миний зүгээс үзэж буй хэд хэдэн асуудлуудыг онцлон тэмдэглэмээр байна.

Одоогийн хуулийн төсөлд ихэвчлэн цагдаагийн хамгаалалтаас бүрдсэн хязгаарлагдмал, богино хугацаанд хамгаалах арга хэмжээнүүдийг тусгажээ. Миний зүгээс эдгээрийн оронд хамгаалалтын талаархи өргөн хүрээний, нэгдсэн ойлголтыг бий болгохыг зөвлөж байна. Энэ нөхцөлд механизмын гүйцэтгэх үүрэг нь хүний эрхийн хамгаалагчдын ажилд саад болж буй айлган сүрдүүлэх, ялгаварлан гадуурхах, шийдвэр гаргах үйл явцад оролцуулалгүй орхих, гэмтнийг ял шийтгэлгүй өнгөрөөх гэх мэт бэрхшээлүүдийг шийдвэрлэх төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх ажлуудаас бүрдэх хэрэгтэй. Мөн хуулиар хүүхэд, эмэгтэйчүүдийн хүний эрхийн хамгаалагчид, байгаль орчны хамгаалагчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд, үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд, авлигын эсрэг болон шүгэл үлээгчид зэрэг бүхий л хүний эрхийн хамгаалагчдын гүйцэтгэдэг нэн чухал бөгөөд хууль ёсны үүргийг дэмжин сурталчлах, хүлээн зөвшөөрөх, урамшуулах шаардлагатай.

Түүнчлэн, Монгол улс урд нь хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны явцад гэмт хэргийн хохирогч, гэрчийг хамгаалах зорилгоор бий болгосон бие даасан Тахарын үйлчилгээ болон Аюулгүй байдлын хамгаалалтын албатай байжээ. Тухайн үед уг албаны хийж гүйцэтгэсэн ажлыг ихээхэн магтан сайшааж байсан хэдий ч төсөв хөрөнгө дутагдалтайн улмаас 2016 онд татан буулгасан байна. Улмаар тус албаны үүргийг Цагдаагийн Ерөнхий Газарт шилжүүлсэн ч цагдаагийн ажилтнуудыг шаардлагатай нэмэлт арга хэрэглэгдэхүүн, хөрөнгө эх үүсвэр, сургалтаар огт хангаагүй. Миний уулзсан хүмүүсийн зүгээс өмнө байсан Тахарын алба шиг гэрчийг хамгаалах ажлыг хариуцсан бие даасан бүтэц нэгжийг сэргээн байгуулах эрэлт хэрэгцээ маш их байгааг илэрхийлж байлаа. Үүнээс үүдэн миний зүгээс хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалах механизмаас гадна иймэрхүү хөтөлбөрийг дахин бий болгож, хангалттай хэмжээний төсөв хөрөнгө хуваарилахыг зөвлөмж болгож байна.

### **Зөвлөмж**

- Зөвхөн хүний эрхийг хамгаалагчдын эрхийг хамгаалах бус, харин тэдний гүйцэтгэдэг нэн чухал бөгөөд хууль ёсны ажил үүргийг дэмжин сурталчлах, хүлээн зөвшөөрөх, мөн эрхийн хамгаалагчдын эсрэг дайралтыг ял шийтгэлгүй өнгөрөөдөг явдлыг тодорхой замаар таслан зогсоох, шийтгэхийн тулд Хүний эрхийн хамгаалагчдын эрх зүйн байдлын тухай хуулийг батлан хэрэгжүүлэх.
- НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газрын дэмжлэгтэйгээр хүний эрхийн хамгаалагчдын тухай хуулийн ач холбогдлын талаархи, ийм хуулийг аль хэдийнээ баталж хэрэгжүүлсэн улс орнуудаас олон улсын экспертүүдийг урьж оролцуулах боломжтой зөвлөлдөх уулзалт зохион байгуулах.

- Тахарын албаны үйлчилгээг сэргээн бий болгох замаар хохирогч, гэрчийн хамгаалалтыг хууль сахиулах байгууллагаас тусдаа хэлбэрээр институтчилэх.

### **С. Эрсдэлд буй бүлгүүдийн сорил бэрхшээл**

#### **Хүний эрхийг хамгаалагч хүүхэд, залуучууд**

Олон хүнээс миний авсан мэдээллээр Монголд олон хүүхэд хүчирхийлэл, дарамт, үл хайхрах харьцаа, мөлжлөгт өртдөг байна. Энэ хүрээнд хүүхдийн эрхийг хамгаалагчид хүүхдийн нөхцөл байдлыг сайжруулах үйл хэрэгт чухал үүрэгтэй юм. Надтай уулзсан хүмүүсийн зарим нь хүүхдийн ихэнх нь, ялангуяа хөдөө орон нутагт, хүний эрхийг хамгаалагчдын талаар ойлголцогүй байна.

Хүний эрхийг хамгаалагч хүүхдүүдийн томоохон бүлэгтэй би 2019 оны 5 сарын 1-нд уулзсан. Тэд боловсролын чанар, гэр орон дахь нөхцөл байдал, уур амьсгалын өөрчлөлт гэх зэрэг өөрсдийн нь эрхэд хамааралтай асуудлаар хандахад нь насанд хүрэгсэд ба эрх баригчид үл тоох, хөөх байдлаар хандсан тухай хэд хэдэн жишээ дурдсан. Мөн сургуулийн нэр хүндийг хөндөж болзошгүй асуудлыг дэлгэсэн гэх шалтгаар, мөн хүүхдийн насны багаар далимдуулж, багш нар нь хүүхдийг байцаасан, шийтгэсэн тухай тэд мэдээлсэн. Тухайлбал, хүүхдүүд гуравдугаар сард хүний эрхийг дэмжиж, уур амьсгалын өөрчлөлтийг эсэргүүцэж, “Ирээдүйн төлөө баасан гараг” арга хэмжээ зохион байгуулах гэсэн боловч Улаанбаатар хотын захирагч жагсаал хийх өдөр, цаг, байршлыг зөвшөөрөөгүй бөгөөд өөр өдөр, цаг, байршил ч зааж өгөөгүй байна.

#### **Зөвлөмж**

- Хүүхэд, залуучууд өөрсдөд нь нөлөөлөх бодлогуудад үр дүнтэй, жин нөлөөтэй оролцохыг дэмжих орчин нөхцөл бүрдүүлэх, үүний дотор эвлэлдэн нэгдэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөг нь бодтой хэрэгжүүлэх

#### **Хүний эрхийг хамгаалагч эмэгтэйчүүд**

Хүний эрхийг хамгаалагчдын асуудалд жендэрийн үүднээс хандахыг эрхэмлэдгийн хувьд миний бие хүний эрхийг хамгаалагч эмэгтэйчүүдтэй уулзалт зохион байгуулсан. Монголд уулзалтуудын үеэр миний сонссон баримтууд хүний эрхийг хамгаалагч эмэгтэйчүүдийн нөхцөл байдал дэлхий даяар ямар байгаа талаарх миний сүүлчийн сэдэвчилсэн илтгэлд өгүүлсэн чиг хандлагыг баталж байна. Хүний эрхийг хамгаалагч эмэгтэйчүүдэд хүний эрхийг хамгаалагч эрэгтэйчүүдэд тохиолддог эрсдэлүүд мөн адил нүүрлэдгийн дээр жендэрээс шалтгаалсан нэмэлт аюул эрсдэл тулгарч байдаг. Өөрөөр хэлбэл жендэрийн талаар, эмэгтэйчүүд гэж хэн болох, эмэгтэйчүүд ямар байх ёстой тухай гүн нэвчсэн ягшмал үзлийн нөлөөгөөр үүссэн онцлог, нэмэлт сүрдүүлэг, заналхийлэлтэй тулгардаг. Хүний эрхийг дэмжсэн, хамгаалсан хүн нь зөвхөн эмэгтэй хүн байгаагийн төлөө тэдэнд халддаг. Хүний эрхийг хамгаалагч эмэгтэйчүүдтэй уулзах үеэр тэднийг онилон давшилж “муу эх”, “муу эгч” болгон гүтгэх, ёс зүйн эрхэм зүйлсийг гутаагсад мэтээр тэднийг харлуулах дайралтууд хийгддэг талаар ноцтой мэдээллүүдийг сонссон. Тэдгээр дайралт нийгмийн сүлжээг ашиглах нь хэвийн үзэгдэл бөгөөд цахим ба цахим

бус орчинд аль алинд эмэгтэйчүүдийг хамгаалсан орон зай бий болгох шаардлагатайг нотолж байна.

### **Зөвлөмж**

- Нийгмийн бүтэц бүхэнд, бүх түвшинд хүний эрхийг хамгаалагч эмэгтэйчүүдийн эрх тэгш, жин нөлөөтэй оролцоо чухал болохыг олон нийтийн өмнө хүлээн зөвшөөрөх.
- Хүний эрхийг хамгаалагч эмэгтэйчүүдэд онцлог бэрхшээл, аюул эрсдэлүүд тулгардгийг хүлээн зөвшөөрч, эрсдэл, заналхийлэл, халдлагын бүхий л хэлбэрүүдийг баримтжуулж, шалган байцаах. Үүний хүрээнд, хүний эрхийг хамгаалагч эмэгтэйчүүдэд халдсан, заналхийлсэн төрийн ба төрийн бус аливаа этгээдүүдэд хуулийн өмнө авчирч, хүний эрхийг хамгаалагчдын хохирлыг арилгах үр нөлөөтэй арга хэмжээ авдаг байх.

### **Газар, байгаль орчны эрхийг хамгаалагчид**

2015 онд хүний эрхийг хамгаалагч наанадаж хоёр хүн (нэг нь байгаль хамгаалагч, нэг нь уул уурхайн зөрчлийг баримтжуулж байсан эрэн сурвалжлах сэтгүүлч) ойлгомжгүй нөхцөл байдалд амиа алдсан байдаг. Аль аль хэргийн тухайд мөрдөн байцаах ажиллагаа, шударга шүүх, хохирлыг арилгах үр дүнтэй арга хэмжээ авагдаагүй талаар иргэний нийгмийн байгууллагууд гомдол гаргасан. Шүүн таслах байгууллагууд эдгээр хэргийг дорвитой шалган байцааж, хүний эрх, байгаль орчны болон бусад байгууллагын гишүүд хадлага, хавчилтаас ангид байх нөхцөл бүрдүүлэхийг миний бие уриалж байна.

Айлчлалын үеэр уулзсан олон хүмүүс байгаль орчны эрхийг хамгаалагчид, малчид, газар, орон байрны эрхийг хамгаалагчид, нийгэм эдийн засаг, соёлын эрхийг дэмжиж уул уурхайн үйлдвэрүүдийн эсрэг тэмцэгч төрийн бус байгууллагуудын ажилтнуудыг сүрдүүлсэн, гүтгэн доромжилсон, заналхийлсэн олон тохиолдлын талаар мэдээлсэн.

Тухайлбал, өнгөрсөн долоо хоногт миний очиж үзсэн Айраг, Сайншанд, Зүүнбаяны орчны малчдын нөхцөл байдал анхаарал татаж байна. Миний хүрч ажилласан ихэнх төслүүдэд компаниуд оршин суугчидтай урьдчилан зөвлөлдөх, олон тохиолдолд төрийн төлөөллийг оролцуулж хэлэлцсэн байдаг боловч үнэхээр хэрэгжиж буй эсэх асуудалд орон нутгийн иргэд, хүний эрхийг хамгаалагчид эргэлзсэн байдаг. Дээрх нутгуудын хүн амын дийлэнх нь малчид бөгөөд тэдний заримын нь бэлчээр уул уурхайн талбайд орсон боловч тэднийг зөвлөлдөөнд уриагүй байна. Мөн зарим тохиолдолд малчин өрхүүд ба томоохон нийгмийн хөгжлийн төсөл санал болгож байгаа компаниудын эдийн засгийн тэнцвэргүй байдлаас шалтгаалан нэрийн төдий зөвлөлдөөнөөс хэтрээгүй байна.

Зарим компани байгаль орчны нөлөөллөө бууруулах арга хэмжээ авдаг мэт, харин зарим нь нөлөөллийг бууруулах арга хэмжээ бага хэрэгжүүлдэг гэж үздэг байна. Жишээлбэл, Айраг суманд БНХАУ-ын Янтай Уул хэмээх компанийн олборлож байгаа фторын уурхайн ойролцоо малчид илэрхий бохирдсон тоосон дунд амьдарч байгааг би харлаа. Мөн Бурханы шашны Хамарын хийдийн хамгаалалтын бүсээс хэсэглэн уул уурхайн компанид эзэмшүүлэхээр олгосонд миний сэтгэл түгшиж байна. Уул уурхайн олборлолт нь тус хийдэд ирэх мөргөлчдийн шашин шүтэх, итгэл үнэмшлийн эрх чөлөөнд

сөргөөр нөлөөлж болзошгүй.

Зүүнбаяны талаарх мэдээлэл усны үүсвэр бохирдсон тухай оршин суугчдын сэжиг таамгийг цайруулсангүй. Компани ба байцагчид олон нийтэд тогтмол мэдээлэл өгч байвал талууд хоорондын үл итгэлцсэн нөхцөл байдал шийдэгдэж болно.

### **Зөвлөмж**

- Хүний эрхийг хамгаалагчидтай зөвлөлдөж, Бизнес ба хүний эрхийн үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, бизнес ба хүний эрхийн удирдах зарчмуудыг түгээн дэлгэрүүлэх, хэрэгжүүлэх, компани, малчид, бусад оролцогч талуудын харилцааг зохицуулах.
- Компаниудад тусгай зөвшөөрөл олгохоос өмнө орон нутгийн олон нийтэд үнэн зөв, олон ургальч мэдээлэл олгож, олон улсын стандартын дагуу үр дүнтэй зөвлөлдөөн явуулдаг байх. Чингэхдээ, нөлөөлөлд өртөх иргэдийн түгшүүр, бодол саналыг анхааран авч байх нь зүйтэй. Компаниуд “нөлөөлөлд өртөх хүмүүс” гэдэг ойлголтыг өргөн утгаар, малчид, нүүдэлчдийг хамруулан хэрэглэдэг болгох нь зүйтэй.
- Олон улсын санхүүгийн байгууллагын дэмжлэгтэй төслүүд хүний эрхэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх, хүний эрхийн байгууллагуудыг төсөлд хяналт шинжилгээ хийж, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцуулдаг байх хэрэгтэй.

### **Бэлгийн цөөнхийн эрхийг хамгаалагчид**

Монгол Улсын Засгийн Газар 2015 оны 12 сард бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаагаар ялгаварлан гадуурхахыг эрүүгийн гэмт хэрэгт тооцсон шинэ чухал нэмэлт өөрчлөлтийг Эрүүгийн хуульд оруулсан билээ. Гэтэл бэлгийн цөөнх, тэдний эрхийг хамгаалагчдын эсрэг нийгмийн хандлага, өрөөсгөл үзэл давамгайлсаар байна. Бэлгийн цөөнхийг ялгаварлан гадуурхах нь хууль сахиулах, эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн бүхий л салбарыг хамарч байна. Бэлгийн цөөнхийн эрхийг хамгаалагчдын мэдээлснээр дээрх тохиолдлуудад шүүх, хуулийн байгууллагад хандах бэрхшээлтэй байна. Олонхи нь өшөө авалтаас айх тул халдлагын талаар мэдээлдэггүй байна. Гомдол гаргаж үзсэн нь цагдаа хэргийг шалгах нь ховор, хэзээ ч шийдэж өгдөггүй гэж мэдэгдсэн.

### **Зөвлөмж**

- Ялгаварлан гадуурхалтын эсрэг тэмцэхэд бэлгийн цөөнхийн эрхийг хамгаалагчдын гүйцэтгэж буй үүрэг нэн чухал бөгөөд хууль ёсны болохыг нийтэд тунхаглах, хууль сахиулах ажилтнуудыг суурь зарчмыг ажилдаа хэрэгжүүлэхэд нь сургах шаардлагатай.

### **Авлигын хэрэг дээр ажилладаг сэтгүүлч, мэдээлэгч, хүний эрхийг хамгаалагчид**

Монголын сэтгүүлчид мэдээллийн хэрэгслүүд цөөн хэдэн хувийн бизнесийн гарт хэт төвлөрсөн, эдийн засаг, улс төрийн хариуцлага хүлээх, шүүн таслагдахаас айхдаа мэдээлэлд цензур тавьдаг, хуурамч мэдээгээр тэжээгдсэн популист гүтгэлэг олон ургальч үндэслэлийг хүлээж авдаггүй хүнд нөхцөлд ажилладаг. Өмнө нь миний хийсэн

ажиглалтаар нэр төр гутаах, мэдээллийн хүртээмжид халдах нь ихэнхдээ юуны өмнө эрэн сурвалжлах сэтгүүлчдийг онилдог байна.

2018–2019 онд 300 сэтгүүлчийн аюулгүй байдлын түвшний талаар хийсэн судалгаа хийсэн Хүний эрхийн байгууллагаас илгээсэн мэдээллийг үзвэл сэтгүүлчид, тэдний гэр бүлийг сүрдүүлэн заналхийлэх, доромжлох явдал Монголын хоёр сэтгүүлчийн нэгд тохиолддог байна. Үүнд бас хэвлэл нийтлэлд цензур хийх, төлөвлөгөөт нэвтрүүлгийг хориглох, тоног төхөөрөмжийг эвдэх, хураах, мэдээлэл авахад саад учруулах, мэдээллийн үүсвэрийг илчлүүлэхээр дарамтлах тохиолдлууд багтана.

Авлигын эсрэг үгээ хэлсэн хүний эрхийг хамгаалагчид, мэдээлэгчдэд ч мөн адил эрсдэл, бэрхшээл тулгарч байна. Тэдэнд тулгардаг нөхцөл байдлыг дүрсэлж болох гурван нийтлэг жишээг надад мэдээлсэн. Эхний тохиолдолд ил тод байдлыг дэмжин ажилладаг хүний эрхийн байгууллагад 2015 онд Ерөнхий Сайдаас авлигач үйл ажиллагаануудыг зарлаад байвал тус байгууллагад эрүүгийн хэрэг нээнэ хэмээн сүрдүүлсэн захидал ирсэн байна. Хоёр дахь тохиолдолд авлигын хэрэг дээр ажилладаг хүний эрхийн байгууллага төрийн байгууллагаас гүтгэн доромжилсон мэдэгдэл хүлээн авсан ба тус байгууллагыг нийгмийн ажлаас их хэмжээний мөнгө хийдэг хэмээн буруутгасан байна. Гурав дахь тохиолдолд авлигын томоохон дуулианыг илрүүлсэн сэтгүүлчийг цагдаагийн байгууллага мөрдөж, гүйцэтгэх ажиллагаа явуулж, занан сүрдүүлсэн тул өөр аюулгүй байранд түр шилжин суухад хүрсэн байна.

Эдгээр жишээнээс үзэхэд Монгол Улс сэтгүүлч, шүгэл үлээгч, хүний эрхийг хамгаалагчид өш хонзон, ял шийтгэлээс айх аюулгүй ажлаа хийх нөхцөлийг бүрдүүлэх талаар илүү сайн ажиллах шаардлагатай байгаа нотолж байна.

### **Зөвлөмж**

- Мэдээллийн хэрэгслийн бие даасан, олон ургальч байдлыг дэмжсэн бодлоготой болох, түүний хүрээнд хэвлэл мэдээллийг зохицуулах албаны бие даасан байдлыг хангах.
- Төрийн эрх баригчдын болон компаниудын үйл ажиллагааг шүүмжилсэн, мэдээлсэн, илчилсэн тохиолдолд яллах, эрүүгийн хариуцлагад татах, дарамтлах явдлаас хуулийн хамгаалалттай болгох.
- Интернетийн зохицуулалтын бүх тал дээр, түүний дотор мэдээллийн аюулгүй байдлын тухай хуулийг батлахдаа хувь хүний нууц, үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөг хүндэтгэх нөхцөлийг бүрдүүлэх. Тэдгээр эрхийг хязгаарлах тохиолдолд хууль ёс, хэрэгцээ шаардлага, тэнцвэрт зарчмыг ягштал дагаж мөрддөг байх хэрэгтэй.
- Мэдээлэгчдийг хамгаалах хуультай болж, шүгэл үлээгчдийг аливаа өш хонзон, гэмт хэрэгт холбохоос хамгаалдаг болох хэрэгтэй.

### **Г. Олон улсын хамтын нийгэмлэгийн үүрэг оролцоо**

Миний уулзсан олон тооны ТББ болон эрхийн хамгаалагчид тус улсад хууль дээдлэх ёсыг бэхжүүлэхэд олон улсын хамтын нийгэмлэгээс дэмжлэг авах нь чухал болохыг илэрхийлсэн. Би олон улсын хамтын нийгэмлэгт шүүх хурлын үйл ажиллагааг

ажиглах, шаардлагатай бол эрсдэлд орсон эрхийн хамгаалагчдад улс төрийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг замаар хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалах тухай заавар удирдамжуудыг бүрэн хэрэгжүүлэх хүчин чармайлтуудаа бататгахыг хүчтэй зөвлөж байна. Элчин сайдын яамдын хувьд алслагдмал нутагт ажиллаж буй эрхийн хамгаалагчид, олон нийт болон хамгийн эмзэг өртөмхий бүлгийнхний эрхийн хамгаалагчдад хүрч очихын тулд бүс нутгуудаар аялах ёстой.

### **3. Дүгнэлт**

Өнгөрсөн 30 жилийн хугацаанд Монгол улс маш их өөрчлөгдөж, коммунист дэглэмийг халж, институцын хувьд бат бэх, эдийн засаг нь өргөжин тэлсэн, олон намын тогтолцоотой ардчиллыг сонгон замнажээ. Эдгээр томоохон ахиц дэвшил нь Монголын ард түмний хувьд далайцтай хөгжил, дорвитой амжилтанд хөтлөн хүргэсэн байна. Би Монгол улсад ардчиллын стандартуудыг тууштай нэвтрүүлж, иргэний нийгэм, түүний дотор хүний эрхийн хамгаалагчдын оролцоог хангах бат бэх тогтолцоог бий болгох зааварчилгаа өгч байна.

Гэхдээ сүүлийн үед батлагдсан буюу хэлэлцэгдэж байгаа хууль тогтоомжууд болон дахин давтагдсан том хэмжээний авлигын дуулиант хэргүүд нь бий болсон хөгжлийн үр дүнд хэврэг талууд байгааг илчлэн харуулсан. Улс төрийн болон бизнесийн хүрээний хуйвалдаан, ард иргэд нь байгальтайгаа үргэлж зохицон амьдарсаар ирсэн улс оронд шүүх засаглалын ба орчны доройтолд хөтөлж буй сэтгэл түгшээсэн улс төрийн нөлөөлөл нь олон нийтийн дундах Төрийн хууль зөрчсөн гэмт хэрэгтнийг баривчлан шийтгэх чадамжид итгэх итгэл алдрахад нөлөөлсөн. Эрх мэдэл цөөхөн хүний гарт төвлөрснөөс хүний эрх доройтох ёсгүй. Эрхийн хамгаалагч олон нийтийн дунд нийгэм, эдийн засгийн дарамттай холбоотой айдас, биеэ цэгнэх байдал түгээмэл байна. Энэ нь ялангуяа олборлох үйлдвэрүүдийн байгаль орчин болон иргэдэд учруулж буй эрсдэлийг зоригтойгоор илчилдэг, авилга, хууль бус үйлдлийн талаар мэдээлдэг, эсвэл зүгээр л нийгэмд шударга ёс, тэгш байдлыг уриалан дууддаг хүмүүст илүү хамаатай. Энэ нөхцөлд хүний эрхийн хамгаалагчдын тухай хуулийг батлан хэрэгжүүлэх нь нийгэмд хүний эрхийн хамгаалагчдын гүйцэтгэж буй нэн чухал үүргийг хүлээн зөвшөөрөх, дэмжин сурталчлахад шийдвэрлэх ач холбогдолтой. Би Монгол улсыг цаашид хууль дээдлэх ёсыг сахих болон хүний эрхийн хэм хэмжээ, зарчмуудыг дагаж мөрдөх, ард түмний ашиг тусын төлөө тасралтгүй ажиллах чадвартай гэдэгт баттай итгэж байна.

Баярлалаа.

**Хүний эрхийг хамгаалагчийн асуудал хариуцсан НҮБ–ын Тусгай Илтгэгчийн бэлтгэсэн  
Хүний эрхийг хамгаалагчдын тухай хууль, бодлого, стратеги боловсруулахдаа удирдлага  
болгох үндсэн зарчмууд**

Монголд Хүний эрхийг хамгаалагчдын эрхийг хамгаалахдаа, олон улсын Хүний эрхийн тухай хуулийн дагуу НҮБ–ын гишүүн улсууд биелүүлэх ёстой дараах гурван үүргийн хүрээнд ажиллавал зохино:

- Хүний эрхийн зөрчлийг цээрлэх замаар хүний эрхийг хамгаалах;
- Зэвсэглэсэн, хагас цэрэгжүүлсэн болон зохин байгуулалттай гэмт бүлгүүдийн зүгээс гарсан сүрдүүлгийн эсрэг Хүний эрхийг хамгаалагчдын нэрийн өмнөөс оролцох арга хэмжээ авч хүний эрхийг хамгаалах;
- Хүний эрхийг хамгаалагчид эрхээ эдлэн үйл ажиллагаагаа явуулахад нь аюулгүй, хөхиүлэн дэмжсэн орчин бий болгох замаар хүний эрхийг хүндэтгэн сахих.

МУ–ын Засгийн газар нь Хүний эрхийг хамгаалагчдын эрхийг хамгаалах бодлого, стратеги боловсруулахдаа дараах 7 зарчмыг удирдлага болгохыг би зөвлөж байна. МУ–ын Засгийн газар нь:

1. Хүний эрхийг хамгаалагчдын эрхээ мэдэх, эрхээ эдлэхэд нь Хүний эрхэд суурилсан хамгаалалтын аргыг хэрэглэх, мөн хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах, биелүүлэх үүрэг бүхий талуудын чадвар, хариуцлагыг дээшлүүлэх.
2. Хүний эрхийг хамгаалагчид нь үүсэл гарал, үндэс угсаа, соёл уламжлал, илгэл үнэмшил, жендэрийн ялгаатай байж болохыг хүлээн зөвшөөрөх. Анхнаасаа тэд өөрсдийгөө Хүний эрхийг хамгаалагч гэж үзэхгүй, бусдаар ч тэгэж нэрлүүлэхгүй байж болно.
3. Хүний эрхийг хамгаалагчдын эрхийг хамгаалахдаа жендэрийн ялгаанд ач холбогдол өгөх. Эрсдлийн үнэлгээ хийх болон хамгаалалтын механизм боловсруулахдаа зарим хамгаалагч нар бусадтай харьцуулахад хэн болох, юу хийдэг зэргээс хамааран илүү эрсдэлтэй байж болохыг анхаарах.
4. Хамгаалагчдын “бүрэн аюулгүй байдлыг” хангахыг хичээх, ялангуяа тэдний бие махбод, цахим аюулгүй байдал болон нийгмийн сэтгэл зүйн тайван байдлыг хангахад анхаарах.
5. Хамгаалагчид бүгд харилцан хамааралтай гэдгийг хүлээн зөвшөөрөх. Бодлого, стратеги боловсруулахдаа зөвхөн хамгаалагч хувь хүмүүсийн асуудалд төвлөрөхөөс зайлсхийж, бүлэг, байгууллага, орон нутгийн иргэд, хамгаалагчдын гэр бүлийн гишүүд зэрэг эрсдэлд орж болзошгүй талуудын эрхийг мөн харгалзан үзэх.
6. Хүний эрхийг хамгаалагчдын эрхийг хамгаалах бодлого, стратеги, тактик, аргачлал боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцад хамгаалагчдыг өөрсдийг нь оролцуулах. Хамгаалагчдын оролцоог хангах нь тэдний аюулгүй байдлыг хангахад хамгийн чухал хүчин зүйл болно.
7. Хамгаалалтын бодлого нь хамгаалагчдын нөхцөл байдал, онцгой хэрэгцээг бодолцсон, уян хатан, дасан зохицохуйц байх учиртай.



## **10.8 НҮБ–ЫН УЛСЫН ГАДААД ӨР БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД САНХҮҮГИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГААС ХҮНИЙ ЭРХ, ТУХАЙЛБАЛ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХЭЭ БҮРЭН ЭДЛЭХЭД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ ХАРИУЦСАН БИЕ ДААСАН ШИНЖЭЭЧ ХУАН ПАБЛО БОГОСЛАВСКИЙН МЭДЭЭЛЭЛ**

Улаанбаатар хот, Монгол Улс,

2019 оны 9 дүгээр сарын 11–ний өдөр

### **Айлчлал**

Монгол Улсад хийсэн миний албан айлчлал 9 дүгээр сарын 2–ны өдөр эхэлж өнөөдөр дуусгавар болж байна. Өнгөрсөн 10 хоногийн хугацаанд миний бие төрийн өндөр албан тушаалтнууд, төрийн өмчит компани, хувийн хэвшил, олон улсын байгууллага, эрдэмтэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөлтэй нээлттэй, илэн далангүй яриа өрнүүлж чадлаа.

Айлчлалын өмнө болон айлчлалын үед хамтран ажилласан Монгол Улсын Засгийн газарт гүнээ талархаж буйгаа илэрхийлэхийг хүсч байна. Мөн айлчлалын бэлтгэл ажлыг хангахад дэмжлэг туслалцаа үзүүлсэн НҮБ–ын Монгол дахь хамт олонд талархлаа илэрхийлье.

Энэхүү айлчлал дараах дөрвөн үндсэн зорилгыг агуулсан байлаа. Үүнд: а) өр, макро эдийн засгийн бодлогыг хүний эрхийн үүднээс үнэлэх б) ашигт малтмалын үр шимээ нийгэм, байгаль орчны хүртээмжтэй цогц бодлогод хэр хэмжээнд шингээж буй, улмаар хүний эрх болон тогтвортой хөгжлийг эрчимтэй хангахад оруулж буй хувь нэмрийг ойлгох, в) хууль бус санхүүгийн урсгалаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх чиглэлээр гаргаж буй Засгийн газрын зарим хүчин чармайлт, түүнээс хүний эрхэд үзүүлж буй нөлөөллийг судлах; г) дэд бүтэц, уул уурхайн төслүүдэд олгосон зээл болон гадаадын шууд хөрөнгө оруулалтыг хүний эрхийн үүднээс авч үзэх.

Бүхий л улс орнуудад нөөц баялгаа эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ боломжит хамгийн дээд хэмжээнд эдлэхэд зориулах чадвартай эсэх нь тэдгээрийн өрийн дарамт, татварын орлого, нийгмийн бодлого болон байгаль орчны нөхцөл байдалтай шууд холбоотой байдаг гэдгийг юуны өмнө онцлон тэмдэглэхийг хүсч байна.

### **Нөхцөл байдал**

Монгол Улс нь алт, зэс, нүүрс, мөнгө зэрэг байгалийн баялагаар арвин улс. Уул уурхайн салбар улсын эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд 2016 оны байдлаар авч үзэхэд тус улсын нийт экспортын 86 хувийг эзэлж байхад уламжлалт мал аж ахуйн салбар мөн онд нийт экспортын 6 хувийг эзэлж байв.<sup>173</sup> Өнөөгийн эдийн засгийн загвар нь байгалийн баялагийг ашиглах, уул уурхайн салбар улсын эдийн засгийн гол салбар байхад суурилсан байна. 2010–2017 онд уул уурхайн салбар дунджаар төсвийн нийт орлогын 21 хувийг бүрдүүлж байв.<sup>174</sup> 2017 онд энэ салбарын оролцоо 22 хувьд хүрчээ.

---

<sup>173</sup> Монгол Банк, 2017 оны Жилийн тайлан, хуудас. 16.

<sup>174</sup> Дэлхийн Банк, Зохистой бус зээлгүй өсөлт–Орлого, зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх нь, хуудас. 43.

Гэхдээ, байгалийн баялгаас хэт хамаарах нь эдийн засгийн боломж, мөн сорилт авчирдагийг дэлхийн олон улс орон батлан харуулсан. Судалгаанаас харахад, уул уурхайн олборлолт маш их боломж бүрдүүлдэг хэдий ч тогтвортой өсөлтийг бий болгохын тулд хэд хэдэн нөхцөлийг хангасан байх шаардлагатай байдаг. Нөөц баялаг ихтэй байх нь нэг талаар ерөөл хэдий ч энэ нь хөгжлийн үйл явцад бүтцийн, мөнгөний болон бодлогын хана хэрэм босгон өсөлтөд саад учруулах хэлбэрээр хараал болж хувирах нь ч бий.<sup>175</sup> Байгалийн баялаг арвинтай улс орнууд бүтээмжтэй хөрөнгө оруулалт хийх, эдийн засгийг төрөлжүүлэх, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн хөшүүргээр дамжуулан тогтвортой өсөлтийг хангаж, улмаар нийгэм, эдийн засгийн сонирхлын бүлгүүд хооронд зөвшилцөлд хүрч, нийгмийн иж бүрэн цогц бодлогыг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулалт хийж чадаж байна.<sup>176</sup>

### Макро эдийн засаг, өр ба нийгмийн бодлого

Монгол Улсын өсөлтийн үзүүлэлтүүд өнгөрсөн жилүүдэд мэдэгдэхүйц хэмжээнд дээд цэгтээ хүрчээ. 2010 онд 0.697 байсан хүний хөгжлийн индекс 2017 онд 0.741 болж ихээхэн ахиц дэвшилд хүрсэн байна.<sup>177</sup> Гэсэн хэдий ч улсын эдийн засаг ашигт малтмалын үнэ болон эдийн засгийн уналтын циклийн нөлөөнд автан 1996, 2000, 2009 онд ДНБ-ний өсөлт доогуур түвшинд хүрсэн ба (2,5%-аас доогуур) 2009 онд бүр – 1.269% болж буурсан байна.

2010–аад оны эхэн үед Монгол Улсын эдийн засгийн өсөлт гайхмаар өндөр түвшинд хүрч 2011 онд гэхэд 17 хувийн өсөлттэй байв. 2015–2016 онд ашигт малтмалын үнэ огцом унасан явдал нь Монголын эдийн засагт ихээхэн хэмжээгээр нөлөөлж, улмаар энэ нь хүн амд сөргөөр нөлөөлөхөд хүргэсэн байна. Эдийн засгийн тэгш бус байдал, ядуурлын түвшин өнгөрсөн 10 жилд буурах хандлагатай байсан хэдий ч эдгээр он жилүүдэд, эхийн эндэгдэл бараг 2 дахин (2015 онд 26 байснаа 2016 онд даруй 48,6 хүрсэн) өссөн, 5 хүртэлх насны хүүхэд, нялхсын эндэгдэл өссөн байна.<sup>178</sup> Нэн ялангуяа 2014 онд 21,4% байсан ядуурлын түвшин 2016 онд 29.6 хувь болж эрс өссөн байв.<sup>179</sup> Үүний сацуу хүүхдийн амин дэмийн дутагдал 2010–2013 онуудад үргэлжлэн өсөх хандлагатай байсан бол дараах жилүүдэд нь нөхцөл байдал тогтворжиж иржээ. Түүнчлэн эдийн засгийн өсөлт 2016 онд 16 пунктээр бууран 1.2 хувьд хүрсэн бол энэ онд төрийн өр ДНБ-ний 87 хувьтай тэнцсэн байна.

Энэхүү хямралыг даван туулахын тулд Монгол Улс нь Олон Улсын Валютын Сангийн (ОУВС) 3 жилийн хугацаатай 425 сая ам.долларын “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг (ӨСХ) хэрэгжүүлэхээр 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдөр

<sup>175</sup> Катжа Хужо “ Оршил ба Төлөв байдал: Ерөөл үү? Хараал уу? Ашигт малтмалаар баян улс орны нийгмийн бодлогын санхүүжилт”, Палгрэйв, 2012, хуудас. 3–25

<sup>176</sup> НҮБ-ын НБСИ, “Ашигт малтмалын үр шим/түрээс ба Нийгмийн бодлогын санхүүжилт: Сонголт ба Хязгаарлалт” Бодлогын Товч, 2012, [http://www.unrind.org/80256B3C005BCCF9/httpNetITFramePDF?ReadForm&parentunid=C3C55CD888A5AECC1257ACA004C8FA9&parentdoctype=brief&netitpath=80256B3C005BCCF9/\(httpAuxPages\)/C3C55CD888A5AECC1257ACA004C8FA9/\\$file/RPB16e.pdf](http://www.unrind.org/80256B3C005BCCF9/httpNetITFramePDF?ReadForm&parentunid=C3C55CD888A5AECC1257ACA004C8FA9&parentdoctype=brief&netitpath=80256B3C005BCCF9/(httpAuxPages)/C3C55CD888A5AECC1257ACA004C8FA9/$file/RPB16e.pdf)

<sup>177</sup> <http://hdr.undp.org/en/countries/profiles/MNG>

<sup>178</sup> Дэлхийн банк, Нэг хүнд ногдох ДНӨДэлхийн банк (атласын арга), <https://data.worldbank.org/indicator/NY.GNP.RCAP.CD?locations=MN>

<sup>179</sup> Сайн дурын тойм судалгаа, хуудас. 19.

тохиролцсон.<sup>180</sup> Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Япон, Өмнөд Солонгосын Засгийн газрын<sup>181</sup> зээл, тусламжийг оролцуулаад нийт 5.5 тэрбум ам. долларын санхүүгийн дэмжлэгийн нэг хэсэг болсон энэхүү тусламж нь эдийн засгийг тогтворжуулах, хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх, эдийн засгийг сэргээх зорилго бүхий “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд чиглэгдэж буй юм. Энэхүү хөтөлбөр нь төсвийн нэгдмэл байдлыг хангахаас эхлээд хүүхэд, өндөр настнууд болон эмэгтэйчүүд, түүний дотор ялангуяа төрийн албанд ажиллагчдын эрхэнд нөлөөлөхүйц “Хүүхдийн мөнгө” хөтөлбөрийг илүү оновчтой болгох, 2018 он хүртэл төрийн албан хаагчдын цалинг нэмэхгүй байх, 2019 он хүртэл төрийн албан хаагчдын зэрэг дэвийг нэмэгдүүлэхгүй байх, 2019 он хүртэл төрийн албанд нэмж ажилд авахыг хязгаарлах, тэтгэврийн насыг нэмэх зэрэг арга хэмжээг багтаажээ.

Үүний дотор ихээхэн анхаарал татаж буй асуудал нь “Хүүхдийн мөнгө” хөтөлбөрийг өргөжүүлсэнээс үүдэн ОУВС ядуурлыг бууруулахад чиглэгдсэн хоёр хөтөлбөрийн нэгийг (тухайлбал, Ядуурлын тэтгэмжийн хөтөлбөр)<sup>182</sup> хассан. Оновчтой зорилт бүхий нийгмийн хөтөлбөр, нийгмийн бодлогын салбарын үр ашгийг нэмэгдүүлэх зэрэг нь амин чухал хэдий ч нийгмийн хамгааллын бодлого бүх нийтийг хамрах зарчим ямар ч үед энэ салбарын эцсийн зорилго байх ёстой.

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал–2030–ыг батлах замаар тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг бий болгохыг зорьж буй төр, засгийн хүчин чармайлтыг миний бие онцлон тэмдэглэж байна. Энэ асуудлын хүрээнд, миний бие Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 хэрэгжилтийг 2030 онд хүрсэн байвал зохих Тогтвортой Хөгжлийн Зорилгуудтай уялдуулах, ТХҮБ–ын хэрэгжилтэнд системтэй хяналт шинжилгээ хийх нөхцлийг хангах чиглэлд гаргаж буй хүчин чармайлтаа Засгийн газар үргэжлүүлэхийг хөхиүлэн дэмжиж байна. Мөн Засгийн газар Хүний эрхийн үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал нь Монгол Улсын хүний эрхийн олон улсын хууль тогтоомжоор хүлээсэн үүрэгтэй уялдсан байх нөхцлийг хангасан байх нь зүйтэй гэж үзэж байна.

Дунджаар, нийт хүн амын гуравны нэг нь ядуу зүдүү амьдарч байгаа, түүний дотор зарим бүс нутагт нийт хүн амын бараг л тал хувь ядуурлын түвшингөөс доош түвшинд<sup>183</sup> амьдарч буйд сэтгэл зовниж байна. Нийгмийн салбарт өнгөрсөн 10 жилд хуваарилсан төсвийн хөрөнгө төсвийн хумих бодлогын үед ч нэлээд тогтвортой явж ирсэн бөгөөд 2017–2018 оны хичээлийн жилд бага болон дунд сургуульд хамрагдалтын түвшин 98.6 хувь<sup>184</sup> байсан бөгөөд боловсролын салбарт хуваарилдаг нийт төсвийн 18 хувь нь бага болон дунд сургуулийн санхүүжилтэнд зарцуулагдаж байна. Эрүүл мэндийн салбарын тухайд, 2018 онд гэхэд гэр бүл төлөвлөлтийн чиглэлийн үйл ажиллагаанд 1.8 тэрбум төгрөгийн төсөв хуваарилсныг 2010–2017 онтой харьцуулахад буурсан үзүүлэлт бөгөөд эрүүл мэндийн

<sup>180</sup> ОУВС, “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн 5 дахь шатны үнэлгээ ба Өөрчлөлт оруулах болон Гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг хэрэглэхээс чөлөөлүүлэх хүсэлт, 2018 оны 10 сар, хуудас.1.

<sup>181</sup> Бүгд Найрамдах Хятад Ард Улс Монгол банкинд свопын шугамын хугацааг сунгахыг зөвшөөрсөн.

<sup>182</sup> ОУВС, Тав дахь шатны үнэлгээ, хуудас 7.

<sup>183</sup> Монгол Улсын сайн дурын тайлан 2019

<sup>184</sup> Монгол Улсын сайн дурын тайлан 2019, хуудас.21.

салбар гэр бүл төлөвлөлтийн чиглэлээр хүн амд үзүүлэх үйлчилгээний эрэлт хэрэгцээг хангах боломжгүй болсоны үр дүнд үр хөндөлтийн хувь ихээхэн хэмжээгээр өссөн байна.

Бүрэн бус дунд болон бүрэн дунд сургууль төгсөгч эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдийнхээс илүү хэдий ч эмэгтэйчүүд цалин багатай ажлын байранд илүүтэй ажил эрхэлж байна. Ажил мэргэжлийн ялгаатай байдлаас гадна цалингийн зөрүү их хэвээр байгаа бөгөөд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс дунджаар 11.4 хувь илүү цалин авч байна.<sup>185</sup> Нэмж дурдахад, эмэгтэйчүүдийн тэгш бус цалингүй ажлын ачаалал асар их бөгөөд үүнийг төрийн бодлого болон үндэсний тооцоонд оруулах асуудлыг ойшоон авч үзэхгүй байсаар байна.

Өнгөрсөн жилүүдэд Монгол Улсын Засгийн газар олон чухал эдийн засгийн шинэчлэлийг хэрэгжүүлж иржээ. Эдгээрийн заримыг тус улсын эдийн засгийг тогтворжуулах, төсөв, санхүүгийн сахилга батыг сайжруулах зорилгоор ОУВС санал болгосон байна. Ортодокс буюу уламжлалт мөнгөний бодлого нь ерөнхийдөө бол хүний эрхийн хувьд муу мэдээ гэсэн үг.<sup>186</sup> Эдгээр шинэчлэлийн хүний эрхэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг шүүх засаглалын түвшинд ч, гүйцэтгэх салбарын түвшинд ч хийж заншаагүй байна. 2019 оны 3-р сард НҮБ-ын Хүний Эрхийн Комисс Эдийн засгийн шинэчлэлийн хүний эрхэд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ хийхэд баримтлах зарчмыг (цаашид Баримтлах зарчим гэх) батлаад байгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй байх.

Хүний эрхэд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ гэдэг нь эдийн засгийн шинэчлэлийн бодлогын тухайн хүн амын хүний эрхэд үзүүлж буй бодит сөрөг нөлөөг олж тогтоох, үнэлж дүгнэх үйл явцыг хэлнэ. Эдийн засгийн шинэчлэлийн бодлого гэдэгт, жишээлбэл, эдийн засгийн хямрал, өсөлтийн аль ч үед хэрэгжүүлэх төсвийн нэгдмэл байдлыг хангах, бүтцийн өөрчлөлтийн бодлого, төрийн өмчийн хувьчлал, санхүүгийн болон хөдөлмөрийн зах зээлийн төрийн зохицуулалтыг халах, эсхүл татвар, байгаль орчныг хамгаалахад орох өөрчлөлт зэрэг орж болно.

Энэхүү Баримтлах зарчим нь эдгээр бодлого хүмүүсийн хүний эрхэд үзүүлэх нөлөөлөл-үр дагаварыг авч үзсэн эсэх, хөдөлмөрөө шударгаар үнэлүүлэх эрх, орон байр, зохистой амьжиргаагаар хангагдах болон нэр төртэй байх нөхцлийг хангах эсэх, эдгээр өсөлтөд чиглэгдсэн арга хэмжээ нь нийт хүн амын амьдралын чанарыг сайжруулах, тэдгээрт өөрийн хүний эрхийг ухааран ойлгох хэмжээнд дэмжлэг үзүүлэх эсэх, эдийн засгийн шинэчлэлийн санал эмэгтэйчүүдийн нуруун дээрх тэгш бус ачаалалд нөлөө үзүүлэх эсэх зэрэг асуултанд хариулт өгөхөд чиглэгдэнэ. Баримтлах зарчим нь түүнчлэн төр, засгийн бүхий л байгууллага, агентлагууд, төрийн мэдэлд ажилладаг бусад байгууллагууд өөр өөрсдийн эрх мэдлийн хүрээнд богино дунд урт хугацаанд үүргээ гүйцэтгэх явцад хүний эрхийг хамгаалж байхын тулд эдийн засгийн өөрчлөлт, шинэчлэлийн бодлогыг хүний эрхийн үүднээс авч үзэн боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай бодлогын уялдаа холбоогоор хангаж өгнө.<sup>187</sup>

<sup>185</sup> ТХЗ-ийн тойм судалгаа, хуудас 22.

<sup>186</sup> А/94/178.

<sup>187</sup> А/ХЭК/40/57, Зарчим 11

Хүний эрхэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ нь нийт хүн ам, бодлого боловсруулагчид, олон улсын санхүүгийн байгууллагууд, хөгжлийн банкууд, зээлдэгчид, зээлдүүлэгчид, иргэний нийгмийн байгууллагууд болон бусад талуудад эдийн засгийн шинэчлэлийн үр шимийг цөөн тооны этгээд бус, харин бүх нийтээр хүртэх нөхцлийг хангах ерөнхий бүдүүвчээр хангаж өгч буй юм. Эдийн засгийн шинэчлэлийн хүрээнд санал болгож буй арга хэмжээ нь нотолгоонд суурилсан байх, бусад бодлогын сонголттой харьцуулахад хүний эрхийг хамгийн бага түвшинд хязгаарласан байх, эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг бүх цаг үеийн туршид шаардлагатай түвшинд хангахын тулд эдийн засгийн бодлогын зайлшгүй нэг бүрэлдэхүүн хэсэг байх ёстой.

Хэн чухам энэхүү судалгааг Монголд хийх асуудал нь Монгол улсын өөрийнх нь шийдэх асуудал. Эдийн засгийн шинэчлэлийн нөлөөллийн үнэлгээ нь хараат бус, эрүүл, найдвартай, жендэрийн мэдрэмжтэй байх ёстойг Баримтлах зарчим онцолсон байгаа. Нэг боломж гэвэл, жишээ нь Хүний эрхийн Үндэсний Комисс байж болох юм. “Бодлого төлөвлөлтийн хүрээлэн”-г түүний хараат бус байдлыг хангасан байдлаар амжилттай байгуулж чадвал энэ нь мөн хувь нэмрээ оруулж болох юм.

2016 онд батлагдсан Монгол Улсын “Хууль тогтоомжийн тухай” хуулинд бодлогын шинэчлэлийн эдийн засаг, нийгэм, зохицуулалтын нөлөөллийн үнэлгээ хийх талаар тусгаж өгсөн. Гэсэн хэдий ч хуулийн хэрэгжилт тааруу явж ирсэн байна. Миний уулзан ярилцсан хэд хэдэн хүн зайлшгүй хийх ёстой нөлөөллийн үнэлгээг яагаад ажил хэрэг, дадал болгоогүй байгаа талаар тайлбар өгөх техникийн ур чадвар болон хангалттай хэмжээний задаргаа бүхий мэдээлэл байхгүй тухай дурдаж байв. Бусад улс орны туршлагаас харахад эдгээр саад тотгор нь даван туулшгүй бэрхшээл биш юм. Мэдээллийг сайжруулах, холбогдох байгууллагын нөлөөллийн үнэлгээ хийх, үнэлгээг байнга тогтмол хийж байх техникийн чадавхийг сайжруулахыг Засгийн газарт зөвлөж байна.

Өнөөгийн байдлаар Монгол Улсын нийт гадаад өр ДНБ-ний 220 хувьтай, Засгийн газрын гадаад өр ДНБ-ний 58.9 хувьтай тэнцэж байна. Хувийн салбарын өр дотоодын нийт өрийн (ипотек, хэрэглээ, компанийн өр) тал хувийг эзэлж байгаа бол бусад 50 хувь нь ихэвчлэн уул уурхайн корпорацуудын гадаад өр эзэлж байна. Өрийн тогтвортой байдлын судалгаа хүний эрхийн хэмжээсийг авч үзэх ёстой бөгөөд ингэснээр өрийн түвшний эдгээр эрхэнд үзүүлэх нөлөөллийг холбогдох санхүүгийн байгууллагууд зохин ёсоор анхааралдаа авах юм.<sup>188</sup>

Хувийн салбарын өрийн түвшин өндөр байгаа нь эдийн засагт системийн шинж чанартай эрсдэл бий болгодог тул үүнийг ухаалгаар удирдан зохицуулах ёстой. Баримтлах зарчимд зааснаар, улс орнууд ил тод, ардчиллын зарчмаар хэлэлцэгдэн хуулиар тогтоосон туслах арга хэмжээ болон хүүг тогтоох дэглэмтэй байх ёстой. Улс орнууд өрийн хэмжээ хэт ихсэхийг хазаарлах зорилго бүхий дэлхий нийтийн болон дотоодын санхүүгийн зах зээлийн зохицуулалтыг хангахад чиглэгдсэн холимог арга хэрэгслийг ашиглах хэрэгтэй байдаг. Энэхүү холимог арга хэрэгсэл нь зохистой харьцааны зохицуулалт, өрийн тогтвортой байдлын судалгаа шинжилгээ, капиталын хэмжээнд тавих хяналт зэргээс бүрдэнэ.

---

<sup>188</sup> А/ХЭК/40/57, Зарчим 12

Эдийн засгийн төрөлжүүлэлт урт хугацааны хоцрогдолттой явж байна. Миний бие Монгол Улс эдийн засгаа төрөлжүүлэх, өрсөлдөх чадвараа<sup>189</sup> нэмэгдүүлэхийг зорьж буйг тэмдэглэхийн сацуу энэ чиглэлээр цаашид илүү их хүчин чармайлт гаргаасай гэж хүсч байна. Энэ улсад чухам юу дутагдаж байна вэ? гэвэл, 2015 онд баталсан урт хугацааны аж үйлдвэржилтийн бодлогыг<sup>190</sup> хэрэгжүүлэх, үүний сацуу шинжлэх ухаан, инноваци, технологийн салбарт ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийх талаар шийдвэртэй арга хэмжээ авах явдал гэж харж байна. Өнөөдрийн байдлаар Монгол Улс ДНБ-ний өчүүхэн хувь буюу 2017 онд гэхэд ДНБ-ний 0.2 хувьтай тэнцэх<sup>191</sup> хэмжээний хөрөнгийг судалгаа шинжилгээ, технологи, инновацид зориулан зарцуулсан байна.

Монгол Улсын Засгийн газар макро эдийн засгийг тогтворжуулах болон үе үеийн эрх тэгш байдлыг хангахад тус бүр чухал үүрэг гүйцэтгэх Төсвийн тогтворжуулалтын сан болон Ирээдүйн Өв Сан байгуулсаныг сайшаан дэмжиж байна. “Сайн цагийн боломжийг ашиглан нөөц бүрдүүлэх”<sup>192</sup> Монгол Улсын хэрэгцээ шаардлагыг хүлээн зөвшөөрч талархахын сацуу уул уурхайн салбар болон бусад дотоодын эх үүсвэрээс татвар, нийгмийн даатгалын шимтгэл хэлбэрээр бүрдсэн төсвийн орлогыг үе үеийнхний болон нийгмийн давхарга хоорондын тогтвортой холбоог бий болгоход ашиглах нь чухал ач холбогдолтой гэдгийг цохон дурдая.<sup>193</sup>

### **Татвар болон хууль бус мөнгөний урсгал**

Монгол улсад, 3 хүртэлх тэрбум төгрөгийн орлоготой компанийн орлогын татвар 10 хувь, түүнээс дээш орлоготой бол 25 хувийн татвар төлж байна. Засгийн газар энэхүү хязгаарыг 6 тэрбум төгрөг болгон өөрчилж илүү олон тооны компаниуд 10 хувийн татварын үр шимийг хүртэх боломж бүрдүүлэхийг зорьж байна.

ОУВС 2018 онд “төсвийн гүйцэтгэл төлөвлөгөөнөөс давсан” талаар бүртгэсэн хэдий ч орлогын татварын тогтолцоо нь 10 хувийн нэг шатлалд суурилсан, үл хөдлөх хөрөнгийн татвар 0.6–1.0 хувь байгаа нь анхаарал татахаар асуудал юм. Үүнтэй холбоотойгоор дотоодын нөөцийг дайчлахын ач холбогдлыг онцлон тэмдэглэхийн зэрэгцээ энэ нь хүний эрх, хүртээмжтэй өсөлтийг хангах нөхцлийг бүрдүүлдэг, дотоодын орлогын өсөлт нь эрүүл дахин хуваарилалт, татварын олон шатлалт горимоос<sup>194</sup> шууд хамаардаг болохыг дурдах нь зүйтэй гэж үзлээ.

Миний уулзан ярилцсан зарим хүмүүс Монголын эдийн засагт сүүдрийн эдийн засгийн эзлэх хувийн жин өндөр байгаа талаар дурдаж байв. Засгийн газар ашиглагдахгүй байгаа төсвийн орлогын ач холбогдлыг үнэлэх зорилгоор судалгаа хийж, татварын орлогыг илүүтэйгээр татан төвлөрүүлэх, түүний зэрэгцээ үүрэг, хариуцлагыг хангаж ажиллах асуудлыг анхааралдаа авбал зүйтэй гэж үзэж байна.

<sup>189</sup> МУ-ын Засгийн газар, Солилцох захидал, 2017 оны 4 дүгээр сарын 13”.

<sup>190</sup> НҮБ-ын ХХ-ийн Бага хурал, Худалдаа ба Хөгжил тайлан 2016.

<sup>191</sup> <http://hdr.undp.org/en/countries/profiles/MNG>

<sup>192</sup> МУ-ын Засгийн газар, Солилцох захидал, 2017 оны 4 дүгээр сарын 13.

<sup>193</sup> НҮБ-ын ШУХСХ-ээс авсан ишлэл

<sup>194</sup> А/ХЭК/40/57, параграф 11.2.

Миний бие Монгол Улсын Засгийн газар 2018 онд “Ил тод байдал ба татварын зорилгоор мэдээлэл солилцох тухай”<sup>195</sup> даян дэлхийн форумд оролцон “Суурийг нурааж, ашгийг дахин хуваарилах тухай хүртээмжтэй зохицуулалт”<sup>196</sup>-д нэгдсэнийг сайшааж байна. Гэсэн хэдий ч татвартай холбоотой гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг 5-аас 4 жил болгож бууруулсан, татварын өршөөлийн хуулийг олон удаа баталсан болоод татварын өршөөл, татварын өршөөлд хамрагдсан татвар төлөгчдийн тухай мэдээлэл олон нийтэд ил тод биш байгаад сэтгэл зовниж байна.

Нэмж дурдахад, Ил тод байдлын олон улсын индексээр Монгол Улс 2017 онд 103 дугаар байрт жагсаж байсан бол 2018 онд 93-т жагсаж, нөхцөл байдал үлэмж хэмжээгээр сайжирсан дүн гарсан билээ. Гэсэн хэдий ч миний уулзсан олон хүн авилгын талаар, энэхүү эдийн засгийн гэмт хэрэг нь төсвийн орлого болон хөгжилд сөрөг нөлөө үзүүлж буй талаар санаа зовнисоор байгаа гэж ярилцлагын үеэр дурдаж байв. Мөн түүнчлэн, бизнесийн салбарт авилга ихээр оршин буй талаар надтай уулзсан хэд хэдэн хүн цохон дурдаж байлаа.

Монгол Улс авилгаас урьдчилан сэргийлэх, авилгатай тэмцэх чиглэлд хүчин чармайлт гаргаж буй хэдий ч оршин буй цоорхойг арилгах шаардлагатай байна. Эрх зүйн баримт бичиг тухайн салбарын холбогдох зарчмыг, тухайлбал, а) ашиг сонирхлын зөрчлийг арилгах – үүний тулд холбогдох хууль эрхзүйн баримт бичгийг боловсруулахдаа эрх мэдлийн тодорхой хуваарилах, хууль ёсыг дээдлэх, захиргааны баримт бичгийг олон нийтэд сурталчлах, шударга ба үр ашигтай байх, тухайн хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх зэрэг зарчмыг удирдлага болгодог байх; б) салбар болгоноос нөлөөлөл үзүүлдэг явдлыг зогсоох; в) олон улсын хүний эрхийн стандартын дагуу мэдээлэгчдийг зүй зохистой арга замаар хамгаалах чиглэлээр үр дүнтэй зохицуулалт хийх хэрэгтэй байна.

Авилгаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхэд шүүх засаглалын хараат бус байдлыг хангах явдал маш чухал. Энэ асуудлын тухайд, Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын асуудлаархи Тусгай илтгэгч, мөн Шүүгчдийн хараат бус байдлын асуудлаархи Тусгай илтгэгч аль аль нь 2019 оны 3-р сард Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулинд оруулсан нэмэлт өөрчлөлт болон Прокурорын тухай хуулинд Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн зөвлөмжийг үндэслэн шүүгч болон прокурорын байгууллагын даргыг ажлаас чөлөөлөх талаар шинэ заалтууд оруулсанд санаа зовниж буйгаа Засгийн газарт хандан илэрхийлж байсан гэдгийг би онцлон тэмдэглэж байна.<sup>197</sup>

Татвартай холбоотой асуудлын тухайд, үндэстэн дамнасан, бизнесийн үйл ажиллагааны нарийн төвөгтэй бүтэцтэй томоохон компаниуд оролцдог уул уурхайн салбар дахь үнэ шилжүүлэх явдал маш чухал асуудалд тооцогддог. Уг асуудлын тухайд төрийн зүгээс хууль тогтоомжийг тов тодорхой, оновчтой болгох замаар үндэстэн дамнасан компаниуд хөрөнгөө эсхүл олсон ашгаа өөр бусад улс орон руу шилжүүлэх, эсхүл булхайтай үйлдэл хийх; гаалийн болон онцгой татварыг төлөхөөс зайлсхийх буюу нуун дарагдуулах зорилгоор үнэ, тоо хэмжээ, чанар болон бусад бараа, үйлчилгээтэй

<sup>195</sup> <https://www.oecd.org/tax/transparency/mongolia-joins-the-global-forum-on-transparency-and-exchange-of-information-for-tax-purposes.htm>

<sup>196</sup> <http://www.oecd.org/tax/beps/inclusive-framework-on-beps-composition.pdf>

<sup>197</sup> MNG 1/2019.

холбоотой тоон мэдээг санаатайгаар буруу ташаа, нягт нямбай бусаар мэдүүлэх явдлыг хууль бус гэж үзэхийг Бие даасан шинжээчийн хувьд би зөвлөж байна. Түүнчлэн, гаалийн ажилтнууд нь экспорт, импортын талаар судалгаа шинжилгээ хийх, нэмэлт шүүлт<sup>198</sup> шаардлагатай шилжүүлгийг олж тогтоохын тулд олон улсын худалдаанд хэрэглэгддэг бараа, бүтээгдэхүүний харьцуулах үнийн мэдээллийн системийг ашигладаг болохыг Засгийн газраас гаалийн байгууллагад үүрэг болгохыг зөвлөж байна.

Оюу толгойн уурхайг хөгжүүлэх талаар 2009 онд Монгол Улсын Засгийн газар Рио Тинто–той байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээ нь тус улсын татварын нөхцөл байдалд мэдэгдэхүйц үр дагавартай гэрээ юм. Тухайлбал, уг гэрээний татварын тогтвортой байдлын тухай заалт нь 30 жил хүчинтэй буюу энэхүү гэрээгээр тохирсон татварын хувь хэмжээ 3 арваны туршид мөрдөгдөхөөр заагджээ. Цаашилбал, гэнэтийн ашиг болон ер бусын ашигт татвар ногдуулах эсэх асуудлаар санал зөрөлдөөнтэй байна.

Миний хувьд, татварын тогтвортой байдлын тухай энэхүү заалтыг наад зах нь хоёр өөр өнцгөөс авч үзэж болохоор байна. Нэгд, энэхүү уул уурхайн төслийн гол зорилгуудын нэг нь хүртээмжтэй өсөлтийг хангах явдал гэдэг талаас нь авч үзвэл, Монгол Улсын байгалийн баялагийг ашиглан үйлдвэрлэл явуулж олсон ашгийг зуун хувь хувийн хэвшлийн мэдэлд өгнө гэдэг нь нийгмийн болон улс төрийн талаасаа зөв зүйтэй гэж үзэхэд буюу нотлоход хэцүү юм. Хоёрт, олон улсын хууль эрх зүйн талаас нь авч үзвэл, тогтвортой байдлын тухай заалтыг гэрээнд оруулж байх үед тодорхой хэмжээний ашгийг урьдчилан тооцоолоогүй байсан бөгөөд нөхцөл байдал үндсээрээ өөрчлөгдөх (компанид гэнэт их ашиг орж ирэх зэрэг) нөхцөлд Монгол улс, хөрөнгө оруулагч хоорондоо уг ашгийн хуваарилалтын талаар хэлэлцэж болохоор байна.

Энэхүү санал зөрөлдөөнтэй асуудлыг шийдвэрлэх нэгэн арга зам нь гэрээг дахин авч үзэж хэлцэл хийх замаар зах зээлийн үнэд суурилсан хөвөгч роялти хэрэглэх хувилбарыг сонгох хувилбар байж болох юм. Уг системийг Монголд үйл ажиллагаа явуулдаг хэд хэдэн уул уурхайн бизнес амжилттай хэрэгжүүлж байна. Хөгжил гэдэг нь зөвхөн эдийн засгийн өсөлтийн үр шимийг хуваалцах тухай бус нийгэмд учруулсан хор хохирлын хариуцлагыг ч нэгэн адил хуваалцах тухай гэдгийг мартаж ёсгүй.

### **Уул уурхай, байгаль орчин ба хүний эрх**

Уул уурхайн үйл ажиллагаанаас олж буй ашгаас шударгаар хүртэх, өөрсдийн үе удам дамжин ашиглаж ирсэн газар нутгийг нь ашигласны төлөө тухайн орон нутгийн иргэдэд хангалттай хэмжээний нөхөн төлөөс болгож хөрөнгө оруулалт хийх зорилгоор “Орон нутгийн хөгжлийн гэрээ” байгуулах асуудал миний анхаарлыг татсан юм. Харамсалтай нь амьдрал дээр эдгээр нь тэр бүр бүрэн хэрэгжээгүй байх буюу уул уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн нутгийн иргэдийн тухайд бодитой үр өгөөжөөгч чадахгүй байна. Олборлох салбарын үйл ажиллагаанаас малчин түмний эдийн засаг, нийгэм, соёлын эрх, түүний дотор бэлчээр, малын тэжээл бэлтгэдэг газар нутаг, усны нөөцөд үзүүлж буй нөлөөллийн талаар Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны санаа зовниж буйтай миний бие санал нэг байна.

---

<sup>198</sup> А/ХЭК/31/61.



Эдийн засаг нь уул уурхайн салбараас ихээхэн хамааралтай улс орны тухайд байгаль орчны нөлөөллийн үнэлгээний ач холбогдол туйлын чухал юм. Хуулинд зааснаар, уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохын өмнө ийм үнэлгээ хийгдсэн байх шаардлагатай. Түүнчлэн, үйл ажиллагаа явуулж байгаа үед болон мөн үйл ажиллагаа зогссон үед нөлөөллийг үнэлэх хяналт үнэлгээний тогтолцооны талаар Монгол Улсын хууль эрх зүйн баримт бичигт тусгаж өгсөн байдаг. Эдгээр үнэлгээ нь гагцхүү байгаль орчны асуудлыг хамраад зогсохгүй нийгэм, эдийн засгийн шинж чанартай зарим асуудлыг хэсэгчлэн авч үздэг хэдий ч 2019 оны 5 дугаар сард Хүний эрхийн Үндэсний Комиссын хийсэн “Таван толгойн нүүрс олборлолт, тээвэрлэлтийн нөлөөллийн үнэлгээний цогц тайлан”-тай харьцуулшгүй юм. Нөлөөллийн үнэлгээний үр дүнд гарсан зөвлөмжийн дагуу дэд бүтэцтэй холбоотой зарим асуудлыг Засгийн газраас арга хэмжээ авч шийдвэрлэсэн байна.

Гэсэн хэдий ч, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тогтолцоо нь ашиг сонирхлын дотоод зөрчилтэй байгаа нь миний олж мэдсэн санаа зовоож буй асуудал юм. Уул уурхайн компаниуд нь эрх бүхий хувийн зөвлөх компанийг сонгож, гэрээ байгуулж, төлбөрийг нь төлж байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээ хийлгээд Засгийн газарт хүлээлгэн өгдөг. Үнэлэгч нь үнэлгээ хийлгүүлэгчээс хараат бус байх зарчим хангагдахгүй байна. Ямар ч тохиолдолд, төрөөс үзүүлэх үйлчилгээг хувийн компаниар эсхүл гуравдагч этгээдээр гэрээлэн гүйцэтгүүлж байгаа явдал нь Засгийн газрыг олон улсын хүний эрхийн тухай хуулийн хүрээнд хүлээсэн үүргээс нь ямар нэг байдлаар чөлөөлөхгүй, мөн хувийн хэвшлийн компаниудыг ч одоогийн мөрдөгдөж буй хууль эрхзүйн агуулгын болон процедурын шинж чанартай стандартыг мөрдөхөөс чөлөөлөхгүй юм.

Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахыг хүсч буй уул уурхайн компаниас төлбөр авч үнэлгээ хийдэг хувийн зөвлөх компаниуд нь хамааралтай байдаг явдлыг таслан зогсоохын тулд Засгийн газар өөрийн бүтэцэд мэргэжлийн, хараат бус бодлогын үнэлгээ хийдэг чадавхийг бий болгох хэрэгтэй. Засгийн газар мөн үнэлгээний үйл явцад тухайн нутгийн иргэд, иргэний нийгмийн оролцоог хангах, тэдний чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах хэрэгтэй.

Байгаль орчны яаманд байгаль орчны холбоотой тусгай зөвшөөрлийн аудитын газрын орон тоог нэмэгдүүлэх талаар зөвлөмж өгсөн Хүний эрх, хүрээлэн буй орчны асуудлаархи НҮБ-ын Тусгай илтгэгчийн 2017<sup>199</sup> онд хийсэн айлчлалын дараа гарсан дэвшлийг би онцлон тэмдэглэхийг хүсч байна. Гэсэн хэдий ч өнөөдрийн байдлаар, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд бүхий л уул уурхайн төслүүдийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хянаж залруулга хийх чиг үүрэг бүхий долоохон хүнтэй хэлтэс ажиллаж байгаа бөгөөд эндээс харахад, Монгол улсын уул уурхайн салбарын ач холбогдол болон энэ салбарын байгаль орчин болон хүний эрхийн асуудалд үзүүлдэг нөлөөллийн далайцыг бодолцон энэхүү чухал үүрэг хариуцлагыг гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцөд нэн даруй хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байна.

Монгол Улсын уул уурхайн томоохон төсөл болох Оюу толгойн уурхайд зочлох боломж надад олдсон юм. Энэхүү айлчлалыг зохион байгуулсан, компанийнхаа

---

<sup>199</sup> А/ХЭК/37/58/Нэмэлт.2, параграф. 31.

байгууламжид нэвтрэх бүрэн эрх олгож, шаардсан мэдээллийг гаргаж өгсөн Оюу толгой компанид талархлаа илэрхийлэхийг хүсч байна.

Оюу толгойн уурхай нь бүс нутгийнхаа газар нутагт мал сүргээ бэлчээн, цөлийн хомсхон усны нөөцөө ашиглан үе дамжин амьжиргаагаа залгуулж ирсэн нүүдлийн малчин түмний нутаг болох говь цөлийн өмнөд хэсэгт үйл ажиллагаа явуулж байна.

Оюу толгойн өнгөрсөн жилийн борлуулалтын орлого 1,180 сая ам. долларт хүрсэн бөгөөд төсөвт нийт 200 сая ам. долларын татвар, шимтгэл, бусад төлбөр төлжээ.<sup>200</sup> Уул уурхайн энэхүү төсөлд ил уурхайн болон 2021 онд ашиглалтанд орох гүний уурхайн ажилтнуудыг оролцуулаад нийт 15,000 гаруй ажиллагсад<sup>201</sup> ажиллаж байна. Төслийн 1 дэх үе шат аль хэдийнээ ач холбогдлоо өгсөн бөгөөд Оюу толгойн үнэ цэнийн 80 хувь нь газрын гүнд оршин буй аж.<sup>202</sup> 2017 оны байдлаар ил уурхайгаас нийт 157,400 тонн зэс, 114,000 унц алт, 974 000 унц мөнгө тус тус олборложээ. Оюу толгойн 34%-ийг Засгийн газар (Эрдэнэс Таван Толгой), үлдсэн хувийг Рио Тинто дийлэнх хувьцааг нь эзэмшдэг Туркойз Хилл Ресорсес ХХК өмчилж байна. Уг төсөл нь Рио тинтогийн хөрөнгө оруулалт, Засгийн газрын оролцоо, төрийн болон хувийн хэвшлийн зээлдэгчдийн, үүний дотор ЕСБХБ болон Дэлхийн банкны хувь оролцоотойгоор хэрэгжиж байна.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа аюулгүй ажиллагааны хамгийн өндөр түвшний стандартыг мөрдөж буй нь мэдэгдэхүйц байв. Мөн бүс нутагтаа ажлын байр шинээр бий болгох, худалдан авалтын үйл ажиллагаагаар дамжуулан орон нутгийн бизнесийг дэмжих чиглэлээр хүчин чармайлт гарган ажиллаж буй бөгөөд 2018 оны байдлаар гэхэд нийт ажиллагчдын 95 хувь монгол ажилтан байсан байна. Ажиллагсдын тухайд жендэрийн тэгш байдлыг хангах зорилго тавьдаг бөгөөд эмэгтэйчүүдэд илүүтэй эрх тэгш боломж олгож байна. Эдгээр хүчин чармайлтыг эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн тэгш бус цалингүй ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилготой бодлоготой уялдуулбал зүйтэй гэж үзэж байна.

2012 болон 2013 онд нутгийн малчдын бүлгүүд Дэлхийн банкны Омбудсмены газарт уг уурхайн 2004 оны нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө, 2011 оны эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийн нөхөн олговрын хөтөлбөрийн талаар гомдол гаргасан байна.<sup>203</sup> Эдгээр гомдол нь уурхайн үйл ажиллагаа нь ирээдүйд усны нөөцийн хомсдолд хүргэх, бэлчээрийг доройтуулах, нутгийн иргэдийн өв соёл, уламжлалд аюул занал учруулахтай холбоотой асуудлаар санаа зовниж буйгаа тоймлосон байна. Тэд мөн хангалттай хэмжээнд нөхөн олговор олгогдсон эсэхэд эргэлзэж байна хэмээсэн байв. Хэд хэдэн жил дамжсан эвлэрүүлэн зуучлалын үйл явцын үр дүнд 2017 онд Оюу толгой, орон нутгийн засаг захиргаа, нутгийн иргэдийн хооронд гурвалсан гэрээг байгуулж тохиролцоонд хүрч чаджээ. Миний бие эвлэрэн зуучлалын үйл явцад оролцсон бүхий л гурван талын оролцоонд хүндэтгэл үзүүлэхийн сацуу холбогдох талуудын хүчний тэнцвэргүй байдлыг яриа хэлцлийн явцад анхаарч, олон жил дамжсан хэлцлийн үр дүнд нэгдсэн ойлголцолд хүрч чадсаныг сайшааж буйгаа илэрхийлэхийг хүсч байна.

<sup>200</sup> Оюу толгой, "Жилийн тойм судалгаа-2018," хуудас 18-19.

<sup>201</sup> Оюу толгой, "Өнгөрсөн, өнөө ба ирээдүй, хураангуй хувилбар," 2018 оны 8-р сар, хуудас. 42.

<sup>202</sup> Оюу толгой, "Өнгөрсөн, олоо ба ирээдүй, хураангуй хувилбар," 2018 оны 8-р сар, хуудас. 16.

<sup>203</sup> [http://www.cao-ombudsman.org/cases/document-links/documents/CAOCommunique\\_MongoliaOTClosure\\_March2019\\_ENG.pdf](http://www.cao-ombudsman.org/cases/document-links/documents/CAOCommunique_MongoliaOTClosure_March2019_ENG.pdf)

Оюу толгой нь ашигласан газрын гүний усныхаа 80 хувийг цэвэршүүлээд эргүүлэн ашиглаж буй хэдий ч маш их ус шаарддаг уурхай юм. Малчид, нутгийн иргэд, Ханбогд сумын засаг захиргаа Оюу толгойн төсөл эхэлсэнээс хойш худаг, булаг шанд хэрхэн аажмаар ширгэж байгаад ихээхэн санаа зовниж буйгаа илэрхийлж байв. Мэдээжийн хэрэг, усны хангамж нь говь цөл нутгийн нүүдэлчин иргэдийн хувьд чандмань эрдэнэ, тэдний амьжиргааны эх үндэс шүү дээ. Мега төслүүд нь усны эх үүсвэр, хүртээмж болон чанартай холбоотой хүний эрхэд олон тооны нөлөөлөл үзүүлж болно. Шаардлага хангасан орон сууцаар хангагдах, эрүүл мэндтэй холбоотой зэрэг бусад эрх ч мөн адил хөндөгдөнө.<sup>204</sup>

Үүний үр дүнд, Оюу толгой малчдыг гүний худгийн усаар хангах хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Гэсэн хэдий ч энэхүү шийдэл нь зарим хүндрэлтэй учирч байгаа юм байна. Нэгд, энэхүү шийдэл бэлчээрийн усгүйдлээс сэргийлж чадахгүй бөгөөд говь цөл нутгийн биологийн олон янз байдалд эргэлт буцалтгүй үр дагавар бий болгохоор байна. Хоёрт, малчид цөлд байгуулсан гүний худгаас ус авахын тулд моторт насос ашиглах шаардлагатай болсон байна. Малчид бүгд насос ашиглах эдийн засгийн боломжгүй бөгөөд энэхүү бодит нөхцөл байдал нь тэдгээрийн мал аж ахуйгаа эрхлэхэд сөрөг нөлөө үзүүлж байна. Цөл дөх газрын гүний ус нь туйлын эмзэг бөгөөд маш бага хэмжээгээр нөхөн сэргээгддэг тул гүн рүү явах тусмаа усны хүртээмж багасч, усан хангамж илүү хүндрэлтэй байх болно. Гуравт, усан хангамж хүндрэлтэй болох тусам цөөн хэдэн гүний худгаас хамааралтай болсон тул малчдын малаа тууж оторлон нүүдэллэх хэв маягт ихээхэн өөрчлөлт орсон байна. Өвөг дээдсээс уламжилж ирсэн дадал заншил өөрчлөгдсөөр байна. Ашиглагдаж эхлээгүй байгаа гүний уурхай нь уг төслийн хамгийн том үе шат тул гүний уурхайн хүний эрх болон нийгмийн нөлөөллийн үнэлгээг (нэн ялангуяа малчдад үзүүлэх нөлөөллийн үнэлгээг) хийх замаар нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах, болзошгүй үр дагаврыг арилгах нөхцлийг бүрдүүлэхийг уриалж байна. Уг нь бол энэхүү нөлөөллийн үнэлгээ аль хэдийнээ хийгдчихсэн байх ёстой байв. Миний бие түүнчлэн, хөрөнгө оруулагчдын үүрэг, хариуцлагын тухай асуудлыг энд цохон тэмдэглэмээр байна.<sup>205</sup>

Миний бие зөвлөхөд, богино хугацаанд Оюу толгой компани нь нутгийн иргэдтэй хийх яриа хэлцлээ олон улсын хүний эрхийн стандартын дагуу бүхий л талуудын шаардлагыг хангасан шийдэлд хүрэх хүртэл үргэлжлүүлэх эсхүл төслийг үргэлжлүүлэхэд шаардлагатай усны хангамжийн бусад хувилбарыг авч үзэх хэрэгтэй. Цаашид МУ-ын Засгийн газар нь тулгамдсан асуудлуудаар тогтмол хэлэлцүүлэг явуулдаг олон талд байнгын үйл ажиллагаатай механизмыг бий болохыг зөвлөж байна. Уг механизмд зайлшгүй оролцох талууд нь уул уурхайн компаниуд; нөлөөлөлд өртсөн иргэдийн бүлгүүд; мөн уул уурхай, байгаль орчин, хүний эрхийн асуудал хариуцсан төрийн байгууллагууд байх юм.

Ус, газар, хоол хүнс, амьжиргаа, орон сууц, соёлын зан үйл, өв соёлын хүртээмжтэй холбоотой хүний эрхийн асуудал эрсдэлд ороод байна. Иймд, “Уламжлал ёсоор ашиглаж ирсэн хүмүүсийн газраа өмчлөх, ашиглах эрхийн тухай” заасан ОУХБ-ын Уугуул, нутгийн иргэдийн тухай 169 дүгээр конвенцын 14 дүгээр заалтыг хүндэтгэн хүлээн зөвшөөрөх ёстой гэдгийг энд онцлон тэмдэглэхийг хүсч байна. Үүн дээр нэмээд, хүмүүсийн газар

<sup>204</sup> А/74/197; мөн А/ХЭК/39/55/нэмэлт.2-ийг үзнэ үү?

<sup>205</sup> А/74/197, параграф. 69.

нутгаа ашиглах эрхийг хамгаалах, эзэмшдэггүй ч гэсэн уламжлал ёсоор амьжиргаагаа залгуулах, уламжлалт аж ахуйгаа эрхлэхийн тулд ашиглаж ирсэн газраа ашиглах эрхийг хамгаалахад чиглэгдсэн арга хэмжээг тохиромжтой нөхцөлд авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Энэ тухайд, уг конвенци болон Эдийн засаг, нийгэм, эрхийн хороо Ерөнхий тайлбар тэмдэглэл 15 зэрэг хэд хэдэн ерөнхий санал дүгнэлт, ажиглалтандаа “нүүдлийн болон аялагч иргэд уламжлалт нутаг дэвсгэртээ болон тогтоон өгсөн газар нутагт хангалттай хэмжээний усан хангамжтай байх”<sup>206</sup> нөхцлийг хангахын тулд нүүдэлчин хүмүүст онцгой анхаарал хандуулах талаар дурдсан байдаг.

Олон тэрбум долларын Оюу толгой төслөөс гадна Монгол Улсын нутаг дэвсгэрт янз бүрийн хэмжээ, хүчин чадал бүхий олон тооны уул уурхайн төслүүд хэрэгжиж байна. 2016 онд гэхэд уул уурхайн үйл ажиллагаанаас улбаалж 27,078.0 га газар доройтолд орсоноор бүртгэгдсэн байна.<sup>207</sup> Уул уурхайн үйл ажиллагаа нь эрүүл мэнд, орон байр, ус, ариун цэвэр, эрүүл ахуй зэргийг хамарсан хүний эрхэд сөрөгөөр нөлөөлдөг. Бэлчээрт ашигладаг газар нутаг нь олон нийтийн буюу төрийн өмчлөлд байдаг, үүнээс үүдэн малчин өрхүүд нутаг сэлгэх шаардлага гарахад тухайн газар нутгийг малын бэлчээрт ашиглаж буй нутгийн иргэдтэй тохиролцоонд хүрэх тодорхой сорилттой тулгардаг байж болох юм. Уул уурхайн үйл ажиллагаа мөн уурхайд ажиллагсадын эрүүл мэндэд, тухайлбал, зүрх судасны өвчин, амьсгалын замын өвчлөл, мэдрэлийн өвчлөлөөс болж шаналах зэргээр тодорхой хэмжээний сөрөг нөлөө үзүүлдэг.

Уул уурхайн ажилчид, явуулын туслах ажилтнууд, уурхайн эргэн тойронд амьдардаг хүн амд үзүүлдэг эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээг нэн ялангуяа жижиг хэмжээний уул уурхайн компаниудад системтэйгээр хийдэггүй юм байна. Иймд, үүнийг үр дүнтэй хийж хэвшүүлэх, хийж буйд хатуу хяналт тавих, үнэлгээний санал дүгнэлтэнд анхаарал хандуулдаг болохыг зөвлөж байна. Энэ зорилгоор Эрүүл мэндийн яамыг оролцуулаад холбогдох яамдтай хамтарсан бүтэц байгуулах замаар үнэлгээний дүгнэлтийн мөрөөр хийж буй ажлыг хатуу хяналтандаа байлгах, үүний зэрэгцээ байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийж, уг хоёр үнэлгээний дүгнэлтийг нэгтгэн танилцуулдаг байж болох юм.

Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын процедурын тухай хууль тогтоомж суурин бус нүүлгэн шилжүүлэлтийн асуудлыг орхигдуулсан байна. Энэхүү цоорхойг нөхөхийн тулд холбогдох талуудыг оролцуулсан өргөн хэмжээний зөвлөлдөх уулзалтууд зохион байгуулах замаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй олон улсын хүний эрхийн хэм хэмжээ, стандартад үндэслэгдсэн цогц хууль тогтоомжтой болох арга хэмжээ авахыг Засгийн газарт зөвлөж байна. Ил тод байдлыг хангах, зөвлөлдөх үйл авцыг зохион байгуулах, нөлөөнд өртөж болзошгүй хүмүүсийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг нь маш чухал юм.

### **Дэд бүтцийн төслүүд**

Хэд хэдэн томоохон хөрөнгө оруулалт, зээлийн гол зорилго нь улсын эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чиглэгдсэн байна. Эдгээр төслүүдийн үр шимийг хүн ам жинхэнэ утгаар нь хүртэх явдал чухал. Улаанбаатар хотод гэр хорооллын дахин төлөвлөлтийн

<sup>206</sup> E/C.12/2002/11.

<sup>207</sup> Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, Хүний эрх, эрх чөлөөний талаархи нөхцөл байдлын тухай 17 дахь илтгэл, Улаанбаатар хот, 2018 он, хуудас. 20.

хөтөлбөр болон бусад төслүүд хэрэгжиж байна. Эдгээрийн заримд АХБ дэмжлэг үзүүлж байна. Тухайлбал, Улаанбаатар хотын ядуу иргэдийн дийлэнх нь амьдардаг гэр хорооллын суурь дэд бүтэц болон үйлчилгээг сайжруулахад чиглэгдсэн Улаанбаатар хотын нийтийн үйлчилгээ ба гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг АХБ хэрэгжүүлж байна. Энэхүү төсөл нь зам барих, усан хангамжийн дэд бүтэц, нийгмийн үйлчилгээг хөгжүүлэхийг зорьж байна.

Сэлбэ орчимд гэхэд нүүлгэн шилжүүлэлтэнд өртсөн хэд хэдэн өрхийнолон хүний эрх, түүний дотор орон байртай байх эрх ноцтой зөрчигдсөн буюу зөрчигдөхөөр байна. Энэхүү төслийг хангалтгүй боловсруулсан талаархи гомдлыг АХБ-д хүргүүлээд байгаа бөгөөд үүний дотор мэдээлэлд суурилсан зөвлөлдөх уулзалт, нөхөн олговрын тухай асуудлууд орж байна.<sup>208</sup> Саяхан гарсан тайланд дурдсанаар нэлээд тооны оршин суугчдын санал гомдолшийдэгдсэнд сэтгэл ханамжтай байгаа талаар дурджээ. Гэхдээ нөхөн олговортой холбоотой сэтгэл ханамжтай бус хэвээр үлдсэн оршин суугчдын асуудлыг ч шийдэх шаардлагатай гэж үзэж байна.<sup>209</sup> Нэмж хэлэхэд, ийм төрлийн төслийг хэрэгжүүлэхэд нөлөөлөлд өртсөн иргэдийн орон байраар хангах эрх хөндөгддөг, тухайлбал газрын асуудлыг нь шийдэх, сайн дурын бус буюу албан журмаар нүүлгэн шилжүүлэлт хийх зэрэгт, мөн иргэдийн мэдээлэл авах эрх чхөндөгддөг.<sup>210</sup> Үүнтэй холбоотойгоор төслийг хэрэгжүүлэгчдийн зүгээс хүмүүст өөр орон байртай болоход нь хүрэлцэхүйц хэмжээний нөхөн олговор олгох, цаашдаа мэдээлэл сайтай зөвлөлдөх уулзалт (шинэчлэгдсэн мэдээллийн ил тод байдлыг хангах) зохион байгуулж байхыг би санал болгож байна.

Олон улсын зээлдүүлэгчид болон хөгжлийн байгууллагуудтай хийсэн уулзалтын үеэр тэд аюулгүй ажиллагааг хангах, байгаль орчин, нийгэм, жендерийн нөлөөллийн үнэлгээнийхээ талаар тодорхой дүрэм журам мөрддөг талаар танилцуулж байсан хэдий боловч миний зүгээс зөвлөхөд, хөгжлийн түншүүд уул уурхай, эрчим хүч, зам, дэд бүтэцтэй холбоотой төслүүд хэрэгжүүлэхдээ тухайн төслийн хүний эрхэд үзүүлэх нөлөөллийг хүний эрхийн мөн чанар болон горим журмын талаас нь авч үзэн үнэлдэг эрүүл зохицуулалтын тогтолцоо бий болгох шаардлагатай байна.

### **Санхүүгийн салбар**

Эцэст нь, банк, санхүүгийн салбар НҮБ-ын Бизнес ба Хүний эрхтэй холбоотой баримтлах зарчмыг хойшлуулахгүйгээр хэрэгжүүлж эхлэх шаардлагатай байна. Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж байгаа бөгөөд үүнийг үйл ажиллагааныхаа нэгэн тэргүүлэх чиглэл болгох нь зүйтэй гэж үзэж байна.

Банкуудын зээлдэгчээс авах хүүгийн түвшинд хязгаарлалт байдаг бол (өндөр хэвээр байгаа) банк бус санхүүгийн байгууллагын хүүнд ийм хязгаарлалт байхгүй байна. Санхүүгийн байгууллагууд ялангуяа бичил зээлд жилийн 200 хүртэлх хувийн хүү, зарим нөхцөлд өдрийн хүү тогтоож байна. Ийм түвшний хэт туйлширсан хүү тогтоох нь хүнс, орон байртай байх эрх зэрэг иргэний хамгийн наад захын нийгэм, эдийн засгийн эрхээ

---

<sup>208</sup> <https://www.adb.org/sites/default/files/page/42458/mon-45007-004-complaint-form.pdf>

<sup>209</sup> <https://www.adb.org/sites/default/files/page/42458/mon-45007-004-monitoring-report-final-201907-en.pdf>

<sup>210</sup> Эмнести интернешнл, Улаанбаатар хотод шаардлага хангасан орон сууцтай байх эрх хангагдахгүй байгаа нь, 2015.

эдлэхэд шаардлагатай эх үүсвэртэй байх боломжийг бууруулж байна. Эдгээр санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанд хязгаарлалт хийх, мөнгө хүүлэхчанартай бичил зээлийг цуцлах буюу хүчингүй болгох талаар Засгийн газар хөндлөнгөөс нэн даруй оролцох шаардлагатай байна.

### **Дүгнэлт**

Дүгнэж хэлэхэд, уул уурхайн салбар нь Монгол Улсад бодит өөрчлөлтийг авчрах үүрэг гүйцэтгэх шаардлагатай байгаа бөгөөд нийгэм, эдийн засгийн хөгжлийг идэвхжүүлэгч, үеэс үед илүү эрх тэгш байдлыг хангасан, байгаль орчиндоо хүндэтгэлтэй ханддаг хурдасгуур нь байх хэрэгтэй байна. Үүний тулд, макро эдийн засаг, мөнгөний, зохицуулалтын, нийгэм, байгаль орчны болон аж үйлдвэрийн тууштай бодлого хэрэгжүүлэх шаардлагатай. Ашигт малтмалын орлогыг бүрдүүлэх, удирдах, хуваарилах нь энэ л зорилгыг ханган биелүүлэхэд чиглэгдэх учиртай.<sup>211</sup> Энэхүү хүний эрхэд суурилсан арга нь ихэнх олон улсын санхүүгийн байгууллагуудын таамаглаж байгаачлан уул уурхайн салбарын нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэгдэхээр хязгаарлагдахгүй. Бодит байдал дээр харин тэдгээр нөлөөллийг урьдчилан сэргийлэх буюу хамгаалалтын чиглэлээр авч буй арга хэмжээний аль нь ч хүний эрхийн асуудлыг дурдаагүй болох нь харагдаж байна.<sup>212</sup>

### **Айлчлалын тухай мэдээлэл**

Монгол Улсын Засгийн газар нягт хамтран ажиллаж, Гадаад хэргийн сайд, Хууль зүй дотоод хэргийн дэд сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Сангийн яам, Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам зэрэг төр, засгийн байгууллагын албан хаагчидтай уулзалт хийх боломж олгосонд гүнээ талархсанаа илэрхийлэхийг хүсч байна. Үүний сацуу миний бие Ерөнхий прокурорын газар, Монгол банк, Татварын ерөнхий газар, Авилгатай тэмцэх газар, Санхүүгийн зохицуулах хороо, Хөгжлийн банк, Үндэсний хөгжлийн газартай уулзалт хийлээ.

Миний айлчлалын хөтөлбөрийн хүрээнд УИХ-ын гишүүд, ОУВС, ДБ, АХБ, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, хамтын ажиллагааны байгууллагууд, дипломат төлөөлөгчийн газар, иргэний нийгэм, хувийн салбар, улсын үйлдвэрийн газар, судалгааны байгууллагын төлөөлөлтэй хийсэн уулзалтууд мөн багтсан. Түүнчлэн, Оюу толгойн уурхайд биечлэн очиж танилцсан ба Оюу толгой ХХК, Эрдэнэс Оюу Толгой, Ханбогд сумын Засаг дарга, нутгийн иргэдтэй ч мөн уулзалт хийсэн болно.

Цаг зав гарган надтай уулзаж нээлттэй, илэн далангүй яриа өрнүүлсэн нийт хүмүүст гүн талархал илэрхийлье.

---0000---

<sup>211</sup> Паскаль Хатчерь бусад, “Ашигт малтмалын үр шимээр дамжуулан хүүхдийн эрхийг хангахын улс төрийн эдийн засаг. Монгол Улсын кейс судалгаа,” НҮБ-ын шинжлэх ухаан, хөгжлийн судалгааны хүрээлэн, мэргэжлийн өгүүлэл 2016–7, <http://www.unrisd.org/hatcher-et-al>

<sup>212</sup> Эмнести интернешнл, хуудас. 7.

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ТУСГАЙ ИЛТГЭГЧ НАРЫН ТАЙЛАН

Монгол Улсын Засгийн газрын олон улсын Хүний эрхийн гэрээ конвенциудын хэрэгжилтийн талаарх илтгэлүүдийн тайлагналт 2020 оны байдлаар:

Гэрээ	Тайлагнах журам	Хүргүүлсэн илтгэл	Хүргүүлсэн огноо	Халагдсан огноо	Халагдсан хэлэлцүүлэг	Хүлээгдэж буй илтгэл	Хүргүүлсэн байх огноо	Хоцорсон хугацаа
Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт	Соёрхон баталснаас хойш нэг жилийн дотор, түүнээс хойш Хороо шаардсан тухай бүрт тайлагнана. (Ихэнх тохиодолд 4 жил тутам)	1 дүгээр илтгэл	1978.12.20	1980.03.19 1980.03.21	Ээлжит хэлэлцүүлэг: 9	7 дугаар илтгэл	2022.07.28	
		2 дугаар илтгэл	1985.08.02	1986.03.31 1986.04.01	Ээлжит хэлэлцүүлэг: 27			
		3 дугаар илтгэл	1990.11.29	1992.07.16 1992.07.17	Ээлжит хэлэлцүүлэг: 45			
		4 дүгээр илтгэл	1998.04.20	2000.03.22 2000.03.23	Ээлжит хэлэлцүүлэг: 68			
		5 дугаар илтгэл	2009.09.14	2011.03 сар	Ээлжит хэлэлцүүлэг: 101			
		6 дугаар илтгэл	2016.03.30	2017.07.06 2017.07.07				
Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт	Соёрхон баталснаас хойш хоёр жилийн дотор, түүнээс хойш 5 жил тутам тайлагнана.	1 дүгээр илтгэл	1977.10.19 1979.12.06 1981.10.27			5 дугаар илтгэл	2016.06.30	
		2 дугаар илтгэл	1983.10.25 1986.08.27					
		3 дугаар илтгэл	1998.04.21	2000.08.17 2000.08.18 2000.08.28	Ээлжит хэлэлцүүлэг: 23			
		4 дүгээр илтгэл	2011 он					
Эмэгтэйчүүд-ийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц	Соёрхон баталснаас хойш нэг жилийн дотор, түүнээс хойш дөрвөн жил тутам тайлагнана.	1 дүгээр илтгэл	1983.11.18	1986.03.11 1986.03.13	Ээлжит хэлэлцүүлэг: 5			
		2 дугаар илтгэл	1987.03.17	1990.01.30	Ээлжит хэлэлцүүлэг: 9			
		3 дугаар илтгэл	1998.12.08	2001.01.29	Ээлжит хэлэлцүүлэг: 24			
		3-4 дүгээр илтгэл	1998.12.08	2001.01.29	Ээлжит хэлэлцүүлэг: 24			
		5-6-7 дугаар илтгэл	2007.04.12	2008.10.24	Ээлжит хэлэлцүүлэг: 42			
		8-9 дүгээр илтгэл	2014.12.11	2016.02.19				
		10 дугаар илтгэл	2020.04.22					
Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц	Соёрхон баталснаас хойш нэг жилийн дотор, түүнээс хойш 2 жил тутамд тайлагнана.	1 дүгээр илтгэл	1971.07.30		Ээлжит хэлэлцүүлэг: 4			
		2 дугаар илтгэл	1972.08.07		Ээлжит хэлэлцүүлэг: 7			
		3 дугаар илтгэл	1975.04.09		Ээлжит хэлэлцүүлэг: 11			
		4 дүгээр илтгэл	1978.05.05		Ээлжит хэлэлцүүлэг: 19			
		5 дугаар илтгэл	1979.11.05		Ээлжит хэлэлцүүлэг: 21			
		6 дугаар илтгэл	1981.06.22		Ээлжит хэлэлцүүлэг: 24			

АРАВДУГААР БҮЛЭГ

		7 дугаар илтгэл	1982.04.12		Ээлжит хэлэлцүүлэг: 26		
		8 дугаар илтгэл	1984.12.26		Ээлжит хэлэлцүүлэг: 32		
		9 дүгээр илтгэл	1987.02.12		Ээлжит хэлэлцүүлэг: 37		
		10 дугаар илтгэл	1988.10.18		Ээлжит хэлэлцүүлэг: 37		
Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц	Соёрхон баталснаас хойш нэг жилийн дотор, түүнээс хойш 2 жил тутамд тайлагнана.	11-12-13-14-15 дугаар илтгэл	1998.04.20	1999.03.16 1999.03.17 1999.03.19	Ээлжит хэлэлцүүлэг: 54	25 дугаар илтгэл	
		Шалгалтын тайлан илтгэл (RIO)		1997.03.23	Ээлжит хэлэлцүүлэг: 50		
		16-17-18 дугаар илтгэл	2005.09.27	2006.08.08 2006.08.09 2006.08.17	Ээлжит хэлэлцүүлэг: 69		
		19-22 дугаар илтгэл	2014.05.22	2015.12.02 2015.12.03 2015.12.09			
		23-24 дүгээр илтгэл	2018.10.02				
Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц	Соёрхон баталснаас хойш нэг жилийн дотор, түүнээс хойш дөрвөн жил тутам тайлагнана.	1 дүгээр илтгэл	2009.09.23		Ээлжит хэлэлцүүлэг: 45	4 дүгээр илтгэл	
		2 дугаар илтгэл	2016.08.02	2016.08.12			
		3 дугаар илтгэл	2020				
Хүүхдийн эрхийн тухай конвенц	Соёрхон баталснаас хойш хоёр жилийн дотор, түүнээс хойш таван жил тутам тайлагнана.	1 дүгээр илтгэл	1994.12.20	1996.01.10 1996.01.11	Ээлжит хэлэлцүүлэг: 11	6, 7 дугаар илтгэл	2022.09.01
		2 дугаар илтгэл	2003.05.06	2005.05.26	Ээлжит хэлэлцүүлэг: 39		
		3-4 дүгээр илтгэл	2008.03.31	2010.01.13	Ээлжит хэлэлцүүлэг: 53		
		5 дугаар илтгэл	2015.03.03	2017.05.26			
Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц	Соёрхон баталснаас хойш хоёр жилийн дотор, түүнээс хойш дөрвөн жил тутам тайлагнана.	Анхдугаар илтгэл	2011.06.12	2015.04.08		2, 3 дугаар илтгэл	2019.06.13
Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенц		Анхдугаар илтгэл	2018.12.27				